БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН

МОНГОЛ ХЭЛНИЙ ТОВЧ ТАЙЛБАР ТОЛЬ

ЗОХИОСОН
Я. ЦЭВЭЛ

РЕДАКТОРЛАСАН
Х. ЛУВСАНБАЛДАН

30 000 орчим үг

УЛСЫН ХЭВЛЭЛИЙН ХЭРЭГ ЭРХЛЭХ ХОРОО
УЛААНБААТАР — 1966

ӨМНӨХ ҮГ

Манай оронд хөгжсөн шинжлэх ухааны чухал салбар болсон хэл, утга зохиолын бүтээлийн сан жилээс жилд арвижин нэмэгдсээр байна. Энэ санд одоо нэмэгдэн орж байгаа томоохон бүтээлийн нэг бол тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан Я. Цэвэл зохиож, Х. Лувсанбалдан редакторлосон 30 мянган үгтэй Монгол хэлний товч тайлбар толь юм. Монгол хэлний товч тайлбар тольд монгол хэлний үгсийн сангийн зохих хэсгийг багтааж, үг нэгбүрийн утга зүйн ойлголцыг нилээд өргөн хэмжээгээр тайлбарласнаараа урьд өмнө гарсан монгол хэлний толиудаас агуулгаараа нилээд өргөн болсон монгол хэлний үгсийн сангийн судлалын шинэ бүтээл юм.

Үг голийн үгсийн бүрэлдэхүүнд монгол хэлний арвин сангаас хамгийн чухал хэсгийг сонгон оруулж, тэдгээрийн тайлбарт манай орны социалист байгуулалтын явцад өрнөн хөгжиж байгаа үйлдвэр, хөдөө аж ахуй, соёл шинжлэх ухааны ололт амжилтыг тусган, орчин үеийн монгол утга зохиолын хэлний баялгийг нэмэгдүүлэхэд бага бус анхаарал тавьжээ.

Үүгээрээ үг толь бичгийн чанар нилээд дээшилж одоогийн шаардлагыг хангаж чадахуйц болжээ.

Энэ зорилгыг хангахын тулд толь бичгийг зохиох явцдунд Зөвлөлтийн монголч эрдэмтэд, өөрийн улсын хэлний мэрэгжилтэн эрдэмтэн сэхээтэн нарын санал зөвлөлгөөнийг ява ажлыг тус хүрээлэнгээс хэд хэдэн удаа зохиож, түүнийг Эрдлийн зөвлөлийн хуралдаанаар шүүн хэлэлцэж оновчтой чухал саналын дагуу зохих засварыг хийсээр ирсэн билээ.

Үүний үрээр толь бичгийн чанар дээшилж, үгсийн тайлбар олон салаа утгыг бүрэн илэрхийлэн гаргахад уран зохиол, улс төр, шинжлэх ухааны ном зохиол, мөн ардын аман зохиолын тохиромжтой төрөл зүйлээс сонгон авсан жишээгээр тодруулан тайлбарлахад их тус боллоо.

Уул толийг өөрийн ард түмний эх хэлний боловсролыг нэмэгдүүлж, ялангуяа багш, зохиолч, сэтгүүлч, орчуулагч, сэхээтэн нарын бүтээлийн үг хэллэгийг сайжруулахад туслах зорилгоор энэ толийг хэвлүүлэн гаргалаа.

Энэ үндсэн дээр уг толь бичгийг цаашид сэлбэн засч, нягтлан боловсруулах ажил дэс дараалан хийгдэх болно.

БНМА Улсын Шинжлэх Ухааны
Академийн Хэл зохиолын хүрээлэн

1963 оны 12-р сарын 9.

ОРШИЛ

Монголчууд, эрт дээр цагаас эхлэн монгол хэлний янз бүрийн толь бичгийн зүйл удаа дараа зохиосоор ирсэн баялаг уламжлалтай билээ. Монгол хэлний анхны томоохон тайлбар толь бичиг гэвэл Монголчуудын дунд «Хорин нэгт» гэж алдаршсан 1717 оны Манж-монгол үгний 21 дэвтэр тайлбар толь, мөн «Гучин зургаат» гэж алдаршсан 1746 оны Манж үгний 36 дэвтэр тайлбар толь ийм хоёр янзын зүйл хуваасан толь бичиг байв.

Ардын хувьсгалын үед, 1929 онд С. Шагж «Эрэхүйеэ хялбар болгон зохиосон монгол хэлний тайлбар-чандманий эрх» гэдэг толь бичиг зохиосон боловч хэвлэгдээгүй.

1933 онд Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн дэргэд монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь зохиох ажил үүсч, БНМА Улсын Ерөнхий Сайдын 1933 оны 1-р сарын 6-ний өдрийн 4-р тушаалыг биелүүлэхийн тул Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Товчооны гишүүдийн 1-р тогтоолоор тайлбар толийн комиссыг Б. Ринчен, С. Шагж, М. Гомбожав, Ө. Дорж, Я. Цэвэл, Ц. Дамдинсүрэн, Д. Нацагдорж нарын долоон хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулсан билээ. Энэ комисс, ерийн монгол үг, шинжлэх ухааны нэр томьёоноос гадна түүхт хүмүүс, газар орон, аймаг сум, албан байгууллагын нэрсийг хүртэл бүртгэн оруулсан нэвтэрхий толь бичиг зохиохоор төлөвлөж, 1933—1937 он хүртэл ажилласан хугацаандаа Пүрэв гүнгийн орчуулга «36-т тайлбар толийн» бүх үгсийг тайлбарын хамт карталж дуусаад, түүнээс А-гийн төрлийн үсгээр толгойлсон үгсийн аймгийг бүртгэж зохих тайлбарыг хийж хэвлүүлэхээр завдаж байгаад зуурам орхигдсон юм.

Монгол хэл бол манай ард түмний өндөр соёлыг тусгасан баялаг хэл болох тул түүний үгсийн сангийн бүх баялгийг бүртгэн багтаасан бүрэн тайлбар толь гаргах гэвэл төрөл бүрийн ухааны мэрэгжлийн олон хүн, олон жил ажиллаж байж сая бүтээж чадах юм.

Ингэхлээр бид монгол хэлний бүрэн тайлбар толь гаргахын наана монгол хэлний тэр их баялгаас давын өмнө чухал хэрэгцээтэй үгс бүюу орчин цагийн монголын төв аялгуун дээр тулгуурласан бичгийн хэлний үгсийг ихэвчлэн багтааж үгийн утгын тоймыг тайлбарласан товч тайлбар толь гаргаж нийгмийн хэрэгцээний одоогийн шаардлагыг хангахыг зорьсон билээ.

Манай нийтэлж байгаа энэхүү товч тайлбар толь бол нийт ард түмний хэлний боловсролыг дээшлүүлж, орчин цагийн бичгийн хэлийг сурч судлах үйлст тус болгох зорилготой юм. Иймд тус толийн бүтцэд монголын ард түмний аж байдал, эдийн засаг, нийгэм-улс төр, соёлын амьдралтай зайлшгүй холбоотой үгс, манай орны их хөгжлийн хэрэгцээний шаардлагаар гарч байгаа шинэ үг хэллэг, шинэ нэр томьёо шинэ утга ухагдахуунаас ихэд дэлгэрсэн үгсийг аль болохоор багтаан оруулахыг хичээснээс гадна орчин цагийн бичиг зохиолыг унших болон түүхийн бодит байдлыг ойлгоход эрхбиш мэдвэл зохих зарим хуучирсан үгс, утга зохиолд найруулгын талаар хэрэг болох, нилээд дэлгэрсэн аман аялгууны зарим үгсийг оруулсан билээ.

Энэхүү толь бол, монголын бичгийн хэлний үгсийн сангийн хэм хэмжээг тогтоосон журамлах толь бус учир нэг адил уггатай хэдэн үг нэг үгийн янз янз бичлэгийн аль алины нь оруулсан болно. Харин монгол хэлний үгсийн сангаас нэн хуучирч орхигдсон зарим үгс, дав дээр шаардагдахгүй нэр томьёо, газар орны нэрс зэргийг оруулаагүй билээ.

Энэхүү толинд үүний урьд гарч байсан янз бүрийн толь бичиг, уран зохиол, орчуулгын зохиол, сонин хэвлэл, аман зохиол, ардын ярианы хэлний баялгаас хэрэглэгдэхүүн болгон ашигласан бөгөөд үүнд ашигласан толь бичгүүдийн заримыг дурдвал:

1. Хааны бичсэн Манж үгний толь бичиг (Пүрэвийн орчуулга, уг толийн толгой үг, тайлбарыг мөрийн ар завсраар орчуулсан бичмэл, 1913—14 он, 36 дэвтэр).

2. Мөн Хааны бичсэн Манж үгний толь бичиг (Бат-очир, Мишиг нарын орчуулга, гар бичмэл, 1927, 36 дэвтэр).

3. С. Шагж, Эрэхүйеэ хялбар болгон зохиосон Монгол хэлний тайлбар-чандманийн эрх (бичмэл, 1929 он, 4 дэвтэр).

4. С. Шагж, Монгол үсгийн дүрмийн толь бичиг, Улаанбаатар 1937 он.

5. А. Лувсандэндэвийн ерөнхийлөн редакторлосон Монгол-орос толь, Москва, 1957 он.

6. К. И. Черемисов и Н. Г. Румянцев, Монгольско-русский словарь, Ленинград, 1937.

7. К. И. Черемисов, Бурят-монгольско-русский словарь, Москва, 1951.

8. О. Ковалевский, Монгольско-русско-французский словарь, I II III боть, Казань, 1844—1849.

9. К. Голстунский, Монголо-русский словарь, I II III боть, Санкт-Петербург, 1894—1898.

10. A. Mostaert, Dictionnaire Ordos I II III боть, Peking 1941—1944.

11. Улсын нэр томьёоны комиссын мэдээ, цуврал бичиг, зүйлчилсэн товхимлууд болон бусад толь бичгүүд, дэлгэрэнгүй тайлбар толийн комиссын хийж байсан хэрэглэгдэхүүнээс ашигласан болно.

Энэ толийг 15 жил (1949—1964) Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан-хамт олны туслалцаанд дулдуйдаж чармайн оролдож бүтээхдээ ажлын явц дундуур хэлний мэрэгжлийн хүмүүсийн санал зөвлөлгөөнийг байн байн авч, тэдний санал зөвлөлгөөнийг баримтлан, гурав дахин залруулан засч гүйцэтгэсэн билээ.

Энэ ажилд маш үнэтэй санал зөвлөлгөөн өгч тусалж байсан Шинжлэх Ухааны Академийн жинхэнэ гишүүн Б. Ринчен, Ш. Лувсанвандан, Ц. Дамдинсүрэн, Зөвлөлтийн монголч эрдэмтэн Г. Д. Санжеев, Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан А. Лувсандэндэв, Б. Содном, Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан Х. Пэрлээ, Улсын их сургуулийн монгол хэлний багш Д. Чойжилсүрэн, мөн толь бичигт орсон бүх үгсийн тайлбарыг нягтлан үзэж, нэн ялангуяа нэр томьёог оноож тайлбарлах ажилд их хүч хөдөлмөр гаргаж чин сэтгэлээс тусалсан хариуцлагатай редактор, эрдэм шинжилгээний ахлах ажилтан Х. Лувсанбалдан, мөн техник ажлын талаар үнэнхүү чармайлт гаргаж ажилласан эрдэм шинжилгээний ажилтан Б. Барс нарт чин сэтгэлийн талархлаа илэрхийлье. Бас тус толийг эх нооргийг мэрэгжлийн хүмүүсийн санамжлан зөвлөсөн ёсоор анх удаа хянан найруулж засахад зарим толгой үсгүүдээс, зарим үгсийн тайлбарыг ажлын журмаар найруулан засалцах зэргээр туслалцаж байсан Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Н. Наваан-юндэн, Э. Вандуй, Ж. Бадраа, Б. Базилхаан нарт халуун талархлаа илэрхийлнэ.

Миний хариуцаж хийсэн энэ толинд осол омтгой, ташаа саармаг болсон буюу орхигдсон гээгдсэн зүйл, толь судлал, үгсийн сангийн судлалын холбогдол бүхий алдаа дутагдал байж болох бий. Иймд энэ толийг хэрэглэгч нөхөд ажиж мэдсэн алдаа дутагдлыг ариутган засах, санал зөвлөлгөөнөө Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнд ирүүлж байхыг хүснэ.

Зохиогч Я. ЦЭВЭЛ

ТОЛЬ АШИГЛАГЧДЫН АНХААРАЛД

1. Толь бичигт орсон толгой үгийг догол мөрнөөс цагаан толгойн дэс дараагаар тус тус үүр болгон, хэвлэлийн ажиллагааг хөнгөвчлөн хуучин монгол бичгийг уул үүр үгийн эцэст хадмалласнаас гадна толтой үгийг тод хар үсгээр (ОН); тайлбарыг цагаан үсгээр (жилийг дэс дараалан тэмдэглэхэд хэрэглэх уг); жишээг бичмэл цагаан үсгээр *(нэг мянга есөн зуун хорин нэгэн он; бичигт он сар тавих; төрсөн он)*; хэвшмэл хэллэг, хоршоо, холбоо үгийг жижиг тод хар үсгээр (онд орох) (он туулах); он туулах (малын үхэлгүй, урин дулаан болгох); заалт үгийг чигжээтэй цагаан үсгээр (у р г а м а л, а м ь т а н); ишлэл үгийг цагаан үсгээр бичиж дан хаалтад хийсэн *(он онд идээшиж өлөн жилд дассан нутаг, одоогийн шинэ Монголын улаан туг бүрхсэн орон)* (Д. Нацагдорж); хуучин монгол хадмалыг мөн тод хар үсгээр

2. Тус толь бичигт орсон үгсийн утгыг товч тайлбарласан.

3. Зарим үгийн тайлбарын оронд утга ойролцоо үгийг бичсэнээс гадна бас ч тайлбарт нэмэлт болгож утга ойролцоо үгийг тавьсан нь бий. Жишээлбэл:

МӨДХӨН даруйхан, төдхөн, гараад холдоогүй; *мөдхөн ирнэ.*

ЗАВТАЙ зав бий, зайтай, чөлөөтэй ...

4. Зарим үгийн тайлбарын оронд эсрэг утгатай үгийг тавьсан. Жишээлбэл:

ЗӨӨЛӨН хатуу ширүүн, хатан гэдгийн эсрэг утга ...

5. Зарим үгийг хэл зүйн аргаар тайлсан. Жишээлбэл:

НИСЭЛТ нисэх үйлийн нэр; *нисэлтийн хурд*

НИСГЭХ нисэхийн үйлдүүлэх хэв, нисэхэд хүргүүлэх; *тагтаа нисгэх; онгоц нисгэх.*

6. Дуудлага бичлэг адил болович утга өөр үгсийг догол мөрнөөс бичиж ром тоогоор дугаарласан. Жишээлбэл:

БОРШИХ I шингэн юмны чаналт нь хэтэрснээс болж дэндүү хурц амттай аагтай өтгөн болох; *боршсон шөл; цай борших.*

БОРШИХ II бор өнгөтэй болох, борлох.

7. Хэд хэдэн салаа утгатай толгой үгийг бүх гол утгаар нь тайлбарлаж, утга тус бүрийг цэг бүхий араб тоогоор ялгав:

ДУРСГАЛ 1. ач тус, хайр нехөрлөлийн илэрхийлэл; *дурсгалын хөшөө; дурсгал болгон үлдээх; дурсгалын хурал; дурсгалын тэмдэг; дурсгал болгох;* 2. өнгөрсөн үеийн өв соёлоос үлдсэн зүйлс; *бичиг дурсгал; эдийн дурсгал; хөшөө дурсгал;* 3. дуртгал.

8. Гагцхүү холбоо үгээр хэрэглэдэг үг байвал тийм үгийн эхний үгийг толгой гарган, хойно нь давхар цэг тавьж тайлбарласан Жишээлбэл:

АЛДАГ: **алдаг оног** хааяа, заримдаа; *ажилдаа алдаг оног очиж байна.* ᠠᠯᠳᠠᠭ

9. Хэвшмэл хэллэгийн тайлбарыг дан хаалтанд хийсэн. Хэрэв хэвшмэл хэллэгт хэд хэдэн салаа утга байвал а. б. в. гэх мэтчилэн үсгээр дугаарлан салгаж тайлбарласан. Жишээлбэл: **ам дордойх** (садан төрлийн хүмүүсийн хоорондоо бага зэрэг хэрэлдэж муудалцах; *ам дордойвч элэг дордойхгүй* х у у ч); **амь бөхтэй** (а. хялбар үхдэггүй тэсвэртэй; б. хялбар урагддаггүй эд, эдэлгээ сайтай, яс чанар сайтай, в. хялбар ангижрахгүй зүүнги; *өнөөрсөн нийгмийн үлдэгдэл манай ажил дээр амь бөхтэй оршиж байна*).

10. Хоршоо үгэнд х о р ш. гэж заалт хийсэн. Жишээлбэл:

ИДЭВХ мэриймж, чармайлт, санаачлага, мэрийлт; *идэвх гаргах; идэвх сайтай;* **идэвх хичээл; идэвх зүтгэл** х о р ш.. ᠡᠳᠡᠪᠬᠢ

11. Толгой үгэнд багтах дагалдах үгсийг ихэнхдээ эхний үгээр нь баримталж үүр болгон арай дэлгэр тайлсан .Жишээлбэл:

ЗУД гол төлөв байгалийн эрхшээл нөлөөнөөс болж, хүн малын идэш ууш нэн ховордож нийтээр маш их гачигдал үзэх цаг үе; **зуд гачиг, зуд турхан** х о р ш. ; **ган зуд** (зуны цаг хур бороогүйгээс болж газар хэтэрхий гандаж гачигдах цаг үе); **хар зуд** (өвөл цас огт орохгүй, хараар хүйтэрч гачигдах цаг); **цагаан зуд** (өвөл маш их цас орж гачигдах цаг); **өлөн зуд** (идэш уушны зүйл маш ховор цаг); **зуд болох** (ган гачиг тохиох буюу цас шуурга хэтийдэж хүн мал зүдэж сүйдэхэд хүрүүлэх нөхцөл учрах); **зудтай тэмцэх** (зудад нэрвэгдсэн хүн малд туслах); *зуд болоход нохой таргалдаг, зовлон болоход лам таргалдаг* з у й р. ᠵᠤᠳ

Бас ч эцсийн үгийг баримталж зарим үгийг үүр болгосон нь уг толь бичигт буй бөгөөд толь ашиглагчдын хэрэгцээг бодож эхний болон эцсийн үгийг баримтлан үүр болгосон үгсийн аль алинд тайлбарласан буюу эсвэл нэгийг тайлбарлан нөгөөг тайлбарлаагүй.

12. Нэг юмны биеийн олон нэрийг, гол нэрийг дагуулан үүр болгож тайлбарласан. Жишээлбэл:

МАЙХАН бөс даавуугаар хийсэн, модон багана нуруутай оромж, хэлбэр байдал янз бүр; **майхан шаах, майхан татах** (майхан барих); **майхны ам** (майхны үүд); **майхны ваадан** (майхны ам талыг нээх зөрүүлэх хоёр хошуу); **майхны нуруу** (хоёр баганын дээд үзүүр дэх сэнжинд тогтоох урт мод); **майхны шувуу** (майхны багана); **майхны гол** (майхны их биеийн хоёр талын хэц); **майхны сүүл** (майхны бөгсөн этгээдийн нарийн үзүүр); **майхны хаяавч** (майхны хаяа тойрон хийсэн унжлага бөс); **майхны хэц** (майхны олон уулзарт бэхлэн хийсэн олс дээс); **майхны шанаа** (майхны хоёр голын хойд урд хоёр хошуу). ᠮᠠᠶᠢᠬᠠᠨ

13. Хэрэв хэвшмэл хэллэгийн зүйл үгийн хэд хэдэн салаа утгын аль алинд тохирохгүй байвал тус үүрийн эцэст ☆ тэмдэг тавьж тайлбарласан. Жишээлбэл:

ГАНЦ 1. бусадтай хамтраагүй, нэгээрээ, нэг, өрөөсөн; *ганц бие хүн; хүний ганц хүү; уналгын ганц морь; ганц нэг; ганц хүний суудалтай; ганц хүний ор; ганц хүн хүн болдоггүй, ганц мод гал болдоггүй*

з ү й р; **ганц бөхтэй тэмээ** а м ь т а н (Африк, Азийн зарим оронд байдаг тэмээ, сүү ихтэй, аян жинд хэрэглэнэ); 2. зөвхөн, онцлон тусгайлсныг өгүүлэхэд хэрэглэх үг; *ганц малын ажил хийдэг; ганц хүссэн минь тэр; ганц би биш;* ☆ **ганц хуруутах** (хуруунд юм гарч идээлэн буглах).

14. Толгой үгэнд нэр үгийг ганц тооны хэлбэрээр бичсэн боловч олон тооны хэлбэр нь хам олны утгыг илтгэсэн бол тийм үгийг толгой үг болгосон. Жишээлбэл:

БАГАЧУУД бага насны хүүхэд, залуучууд.

БАГАЧУУЛ багачууд.

15. Нэр үгийг нэрлэхийн тийн ялгалын хэлбэрээр бичсэн.

16. Үйл үгийг үйлт нэрийн ирээдүй цагийн хэлбэрээр бичсэн. Мөн үйл үгийн ихэнх хэв байдлыг оруулсан. Зарим адил дуудлагатай үйл үгийн адил дуудлагатай хэвийг ихэнхдээ бөөгнөрүүлэн оруулсан.

17. Толь бичигт дайвар үг, дагавар үг, төлөөний үг, дэс хам тоо, аялга үг, холбоос үг, сул үгийн зүйл орсон бөгөөд тэдгээр үгсийн айг заасан заалт хийгээгүй.

18. Тус толь бичигт хэрэгцээгүй гэж үзээд оруулаагүй үгс: тийн ялгалын болон хамаадахын дагавартай үгс; үйл үгийн захирах хүсэх, цагийг заах хэлбэр, нөхцөл үйлийн хэлбэр, үйлт нэрийн ирээдүй цагийг заах, үйлийн эзнийг заах хэлбэрээс бусад хэлбэрүүд, товчилсон нэрс.

19. Үгийн эцсийн тогтворгүй «Н»-тэй үгсийн «Н»-г дангаар буюу эсвэл жийрэг эгшгийн хамт, бас тогтворгүй «Н» залгасан толгой үгийн үндэс өөрчлөгдөх болбол өөрчлөгдсөн хэлбэрийг хаалтанд бичив. Жишээлбэл:

МӨНГӨ (Н) 1. цагаавтар өнгөтэй, өнгөлөг үнэт төмөрлөг; **алт мөнгө, мөнгө төгрөг, мөнгөн санхүү** х о р ш.; 2. мөнгөлсөн юм; *мөнгөн аяга; мөнгөн хэт хутга; мөнгөн хазаар.*

ЗУРАГЧ (ИН) зураг зурах буулгахад мэрэгжилтэй хүн; *гар зурагч; уран зурагч; гэрэл зурагчин .*

АРАВ (АРВАН) 1. тооны нэр; *ес дээр нэгийг нэмэхэд арав болно; хүний хоёр гарын хуруу нийлж арав болно; арав арваар; арван арав зуу; арван хоног; нэгдүгээр сарын арван ...* •

20. Нэг үгийн хэдэн янз бичлэгийн аль алийг бичиж, тайлбарыг нэг дээр нь бичсэн.

21. Орчин цагийн бичгийн хэлэнд хэрэглэгддэг нэг үгийн өөр өөр хэлбэрийг цөмийг оруулсан:

ГУЙЛАНЧИН 1. гуйдаг этгээд; 2. хөрөнгө ядуу.

ГУЙЛГАЧИН гуйранчин.

ГУЙРАНЧ (ИН) 1. хөрөнгө хогшил юу ч үгүй ядуу хүн; 2. гуйж амьдрагч.

22. Толь бичигт «Үз», «Хар» гэсэн заалт үг оруулаагүй бөгөөд харин үзвэл зохих үгийг тухайн үгийн ард шууд бичсэн.

23. Уг толь бичигт харь хэлнээс зээлдэн авсан үгийн өргөлтийг гэмдэглээгүй. Жишээлбэл:

АРМИ 1. улсын зэвсэгт хүчин; *Зөвлөлтийн арми;* 2. хэд хэдэн корпус, дивизээр бүрдсэн цэргийн том анги нэгдэл; *армийн генерал* (цэргийн цол).

Бас орос хэлээр дамжиж монгол хэлнээ орсон үгст, орос хэлний У (Y)-г одоогийн үсгийн дүрмийг баримтлан монгол хэлний У үсэгт багтаан оруулсан. Жишээлбэл:

БУРЖУЙ буржуйлиг ангид хамаарагдах дарлагч этгээд.

24. Тус толь бичигт үгийн гарлыг тэмдэглээгүй.

25. Тус толь бичигт орсон үгсийн хэрэглэх байдлыг тодорхой болгохын тулд толгой үгийн ихэнхэд жишээ дагалдуулж, зарим жишээнд з ү й р, х у у ч, (үлгэр), (ерөөл) гэх мэтчилэн ишлэл заалт хийсэн.

26. Тус толь бичигт үгсийн сангийн судлалын зарим хэрэгцээтэй гэж үзэж хийсэн заалтуудыг чигжээтэй үсгээр бичсэн. Жишээлбэл: ш и л ж сэн, б и ч и г, х у у ч и р с а н, я р и а, ш о о д с о н, у р г а м а л, а м ь т а н, з у р х а й, ш а ш и н гэх мэт.

27. Хуучин толь бичигт буй ургамал, амьтны нэр томьёог орос, хятад толиор уламжлуулан олдсоныг язгуур, нам, баг зэргийг зааж тайлбарласан. Олж чадаагүй заримыг хуучин тайлбарыг баахан засч оруулсан.

28. тус тольд орсон үгсийг эдүгээ Б Н М А Улсад хэрэглэж байгаа үсгийн дүрмийг баримталснаас гадна орчин цагийн бичгийн хэлийг хуучин монгол бичгийн хэлтэй харьцуулан судлахад зориулан толгой үгэнд хуучин монгол бичиг хадмалласан болно.

МОНГОЛ Ц АГААН ТОЛГОЙ

Аа	Бб	Вв	Гг	Дд	Ее	Ёё
Жж	Зз	Ии	Йй	Кк	Лл	Мм
Нн	Оо	Өө	Пп	Рр	Сс	Тт
Уу	Үү	Фф	Хх	Цц	Чч	Шш
Щщ	Ъъ	Ыы	Ьь	Ээ	Юю	Яя

А

А I 1. а үсэг; а авиа; *а үсэг эрдмийн дээж, аяга цай идээний дээж* з ү й р; 2. үсгээр дугаарлахад нэг гэсэн утга; *аравдугаар зүйлийн* а-д *дурдсан нь; тавдугаар ангийн „а" булэг;* ☆ **а, ма-гүй** (а. бичиг үсэг үл мэдэх; б. яриа хөөрөөгүй; яриа муутай; в. хэлгүй); **а, э-гүй** (а. бичиг үсэг огт мэдэхгүй; б. яриа хөөрөөгүй, дуугай; в. хэлгүй дүлий; г. адармаагүй, гүндүүгүй; томоотой).

А II аху гэдэг үйл үгийн мөхсөн язгуур; *агсан, аж, атал, аюу, ахул, агаад.*

АА I 1. дуудах сул үг; „а", „у" эгшиг орсон нэрийн дараа тусгай бичнэ; *ардууд аа!, сурагчид аа!;* 2. бусад үгтэй хамт хэрэглэгдэнэ; **аа хөө** (эр эм буюу үеийн хүмүүс бие биенийг дуудах сул үг; *аа хөө цаад номоо аваад аль);* 3. дуудахад хариулах сул үг; *Аюуш аа! -аа! ; аа юу гээ вэ?.*

АА II бусад үгтэй хамт хэрэглэгдэнэ; 1. зөвшөөх, сайшаахад; *аа тэг!; аа зөв!; аа даа сайн байна!;* 2. хайрлах өрөвдөхөд буюу үл тоомсорлоход; *аа зайлуул!; аа хөөрхий!;* 3. гаслах харамсахад; *аа халаг тэгэв үү! тэх л байсан юм;* 4. гайхах эргэлзэхэд; *аа тийм үү!; аа тэгээ юу!;* 5. бусдын үгийг лавлан сонсоход; *аа юу гэнээ?; аа, юу гэв?;* 6. болгоомжлоход; *аа, осолдуузай! ;* 7. үл тоомсорлоход; *аа тэр яах вэ!; аа эс мэдсэн биш;* 8. жигших зэвүүцэхэд; *аа лаа лаа, яасан муухай юм бэ! ; аа яа яа яасан хурц хутга вэ!;* ☆ **аа хай** (уухай); **аа хулга** б и ч и г (а. э л э н х у л а н; *аа хулга газар; аа хулга өдөр;* б. дэмий, сул, зүгээр; *аа хулга өнжив);* **аа гуу** (бага хүүхдийг хөөргөн урамшуулахад; *яасан аа гуу бөмбөг вэ?);* **аа ший** (бусдыг түйвээх, бусдын дуу чимээг намхруулахад; *аа ший! аа ший чимээгээ аяд!);* **аа шүү** (тахиа шувууг үлдэн хөөх аялга).

АА III үүр, омог, дээрэнгүй зан; *аа ихтэй хүн; аатай залуу.*

ААВ я р и а. эцэг; *аавын бийд хүн тань, агтны бийд газар тань!.*

ААГ I юмны амтын хүч чадал их, *цайн ааг, аагтай цай.*

ААГ II хүн юмны ид чадал, омог, илч зэргийн үлэмж давуу; *аагтай халуун өдөр;* **ааг омог** х о р ш.; **аагтай хүн** (омогтой хүн); **аагтай залуу** (чадалтай залуу).

ААГ III 1. ирт юмын ирийн уг этгээд, иш хоёрын хоорондох хэсэгхэн газар; *хутганы ааг;* 2. өрөлбө бахь зэрэг хавчих хазах багажийн хүчлэх мохуул завьж; *хайчны ааг; өрөлбийн ааг;* ☆ **ааг зоог хийх** (хүн, үйл үйлдвэр хийхэд аар саар юмаар шалтаглан хойргоших).

ААГА аму тариаг цайлгахад гарах хэмхдэг хивэг хальс; *будааны аага.*

ААГАЛАХ үр тариаг цайлгаж хивэг хальсыг цэвэрлэн арилгах; *будаа аагалах.*

ААГГҮЙ I юмны амтны хүч чадал бага, сул; *ааггүй цай.*

ААГГҮЙ II зориггүй, зүрхгүй.

ААГГҮЙ III даацгүй, даац муутай.

ААГГҮЙВТЭР ааг нь бага.

ААГГҮЙДЭХ ааг нь нилээд багадах.

ААГГҮЙХЭН нилээд ааггүй.

ААГЖИХ I ааг амт улам орох.

ААГЖИХ II ааг чадал нэмэгдэх.

ААГИМ маш халуун; *ааги халуун өдөр.*

ААГИХ ихэд халууцаж гэвдэх; *өнөөдрийн халууныг ааги ядан өнгөрөөв.*

ААГЛАГДАХ ааглахын үйлдэгдэх хэв.

ААГЛАХ 1. дарлах, дээрэнгүй байдал гаргах, ямар нэг юмыг бардам давж дийлэх; *дээрэнгүйлэн ааглах; эрдэм чадлаар ааглах;* 2. хийх үйлдэх юмны хялбаргүй бэрх буюу хир чадлаас хэтрэх; *энэ ажил намайг ааглаад байна.*

ААГЛУУ давуу, ахдуу.

ААГЛУУДАХ ахдах, дэндүү ааглуу байх; *ааглуудсан ажил бэрхтэй байдаг.*

ААГЛУУЛАХ 1. ааглахын үйлдүүлэх хэв; 2. ааглагдах.

ААГТАЙ I амт хүч ихтэй; *аагтай цай.*

ААГТАЙ II 1. чадалтай; **ааг чадал** х о р ш.; 2. идтэй, хавтай; *аагтай сайхан эд;* **ааг хав** х о р ш.; 3. зоригтой; **ааг зориг** х о р ш.; 4. омогтой.

ААГТАЙВТАР нилээд аагтай.

ААГТАЙХАН ааг ихээхэнтэй.

ААГШИХ ааг нь нэмэгдэх шинжтэй болох.

ААДАЙЛГАХ аадайхын үйлдүүлэх хэв; аадгар болгох.

ААДАЙХ аадгар болох, аадгар байх; маадайх.

ААДАЛЗАХ аадас аадас хийх.

ААДАР 1. ширүүн, **аадар бороо** (ширүүн усархаг бороо); 2. з ү й р л э с э н ширүүн авиртай, *аадар зан.*

ААДАС: аадас аадас хийх, аадгар юмны байн байн хөдлөх.

ААДГА: аадга аадга хийх, аадгар юмны үргэлжлэн хөдлөх.

ААДГАНАХ аадга аадга хийх.

ААДГАР богино, тагдгар; *аадгар тарган хүн; аадгар биетэй морь.*

ААЖИВТОР аажуухан.

ААЖИЙ зарим нутагт эх буюу төрөл садны ахмад насны эмэгтэйчүүдийг ингэж дуудна, мөн ажаа, аажаа ч гэнэ.

ААЖИМ тайван, алгуур, удаан, нөр, яаруу тэвдүү биш; *аажим тайван; аажим удаан; алгуур аажим;* **аажим уужим** х о р ш.

ААЖИМДАА яваандаа, цаашдаа, удаандаа, дараа, хожим.

ААЖИМДАХ удаадах, наазгайдах ,дэндүү аажим болох.

ААЖИМДУУЛАХ аажимдахын үйлдүүлэх хэв.

ААЖИМРАХ аажим болох.

ААЖИМСАХ арай аажим болох.

ААЖИМСГАХ арай аажим болгох.

ААЖИМТАХ улам аажим болох.

ААЖИМТГАХ улам аажим болгох.

ААЖИМХАН баахан аажим.

ААЖИМШИГ жаахан аажим; *би аажимшиг хөдлөнө.*

ААЖУУ угийн аажим, үргэлжид аажим, аажуу уужуу х о р ш.

ААЖУУВТАР арай аажуу.

ААЖУУДАХ хэтэрхий аажуу болох.

ААЖУУДУУЛАХ аажуудахын үйлдүүлэх хэв.

ААЖУУРАХ аажуу болох .

ААЖУУРУУЛАХ аажуурахын үйлдүүлэх хэв.

ААЖУУСАХ арай аажуу болох.

ААЖУУСГАХ арай аажуу болгох.

ААЖУУТАХ улам аажуу болох.

ААЖУУТГАХ улам аажуу болгох.

ААЖУУХАН баахан аажуу.

ААЖУУШИГ жаалхан аажуу.

ААЗАЙЛГАХ аазайхын үйлдүүлэх хэв.

ААЗАЙХ аазгар болох.

ААЗАЛЗАХ аазас аазас хийх.

ААЗАС: аазас аазас хийх аазгар юмны байн байн хөдлөх.

ААЗГА: аазга аазга хийх аазгар юмны үргэлжлэн хөдлөх.

ААЗГАНАХ аазга аазга хийх.

ААЗГАР богино, пагдгар, намхан.

ААЛЗ а м ь т а н үерхэг найман хөлтэй, найман нүдтэй, шүлсээрээ өөш тор сүлжин хэрэх шавьж, **аалзны шүлс** (аалзны биеэсээ гаргах тор өөш хэрэх наалдамхай шүүс).

ААЛЗАРХАГ 1. аалз элбэгтэй; 2. аалзархуу.

ААЛЗАРХУУ *аалзтай төстэй.*

ААЛЗШИГ аалз мэт.

ААЛИГҮЙ I 1. ялбалзах, сэртэнтэх, сээтгэнэх, *аалигүй хүүхэн; аалигүйгээс хамаргүй дээр* з ү й р; 2. давтиргүй.

ААЛИГҮЙ II ааш муутай.

ААЛИГҮЙВТЭР баахан ааЛигүй.

ААЛИГҮЙДЭХ I хэтэрхий ааЛигүй зан гаргах.

ААЛИГҮЙДЭХ II ааль муутайн учир тохиромжгүй болох.

ААЛИГҮЙРХЭХ ааЛигүйгээрээ хөөр болгох.

ААЛИГҮЙРЭХ ааЛигүй болох, ааЛиа эвдэх.

ААЛИГҮЙТЭХ ааЛигүй зан гаргах.

ААЛИГҮЙХЭН нилээд ааЛигүй.

ААЛИЛАХ элдэв ааль зан гаргах.

ААЛЬ I зан; **ааль авир, ааль зан** х о р ш..

ААЛЬ II зүгээр, номхон, чимээгүй, аяархан аажим; *би ааль явна; тэр ер нь ааль хүн шүү; та нар ааль бай!; маргааш тийм эртээр яах вэ, ааль яв.*

ААНАЙ 1. байн байн болох юмыг ул тааламжлан өгүүлэх үг; *бас л ааНай шуурга шуурав; тэр хүн ааНай ирэв; ааНай одов;* 2. хийх бүтээх, хөдлөх аашлах зэрэгт удаан аажим; *ааНай хөдөлдөг хүн.*

ААНАЙВТАР баахан ааНай.

ААНАЙДАХ хэтэрхий ааНай болох.

ААНАЙРАХ ааНай болох.

ААНАЙТАХ *ааНай* байдал гаргах.

ААНАЙХАН 1. баахан ааНай; 2. муухан, барагтайхан; *ааНайхан морь байна.*

ААНАЙШИХ улам ааНай болох, тайвших.

ААНАЙШРАХ улам ааНай байдал гаргах, тайвшрах.

ААНДАА энгийн, зүгээр; *ааНдаа явж байна.*

ААР: аар саар бага сага, ялигүй; *аар саар юм авахаар ирэв.*

ААРАХ: аарах гаарах дэмий түйвээх, хэрэлдэн цуугих.

ААРИГ жалга суваг, баржин сархиаг үлэмж газар.

ААРИГЛАХ I 1. ямар нэгэн бүтүү бэртэнгэ зэргийн хоног удааширч идээлэх баалах зэргээр хүндэрч эвэрлэх; *ааРиглаж хүрэн няц болчихжээ;* 2. хүний бие чилэх, хөших, хөндүүрлэх зэргээр хөдлөхөд зовуурТай болох; *цээж ааРиглаж орхижээ.*

ААРИГЛАХ II ааРиг газраар явах.

ААРМАГ хальстай нь талхласан сагагийн гурил.

ААРУУЛ хатаасан аарц; *ааРуул тавих; хорхой ааРуул.*

ААРХАГ дээрэнгүй, омогтой, шартай.

ААРХАХ оморхох, дээрэнгүйлэх.

ААРХУУ дээрэнгүй, оморхог.

ААРЦ шүүсэн цагаа; *нэрмэлийн ааРц; таргийн ааРц.*

ААРЦАГ 1. хүн амьтны хоёр сүүжний уулзар мэн хоёр сүүж ууц ястай нийлэлдсэн дотоод битүү; 2. сүүжний умдаг ясны уулзар; ааРцаг хагалах (мах эвдэхэд умдаг ясыг уулзраар нь салгах), 3. з үйрлэсэн өрөлбө, хайч зэргийн ам бариулын уулзар газар.

ААТ аатай, омогтой, бардам зантай.

ААТАЙ ааГтай, омогтой, дээрэнгүй; *арслан ааТай ч аРганд ордог* з үйр.

ААХАР: ааХар шаахар аар саар.

ААХИЛАХ амьсгаа сүйлж бачимдан түргэн түргэн давхцаж амьсгалах.

ААХЬ: ааХь уухь 1. ааХилан уухилан; 2. сандран бачимдан.

ААШ зан, авир, ааш зан, **зан авир** х о р ш. **олон ааштай** (элдэв зантай); **сайхан ааштай** (зан сайтай); **ааш муутай** (муу зантай).

ААШААР 1. алгуур; **алгуур ааШаар** х о р ш.; 2. дараа, хожим.

ААШГҮЙ ааш муутай, муухай зантай, авиргүй.

ААШЛАГДАХ ааШлахын үйлдэгдэх хэв.

ААШЛАХ 1. авирлах, элдэв янзын авир байдал үзүүлэх; *сайхан ааШлах; муухай ааШлах;* 2. загнах, зандрах.

ААШЛУУЛАХ 1. ааШлахын үйлдүүлэх хэв; 2. ааШлагдах; *би ааШлуулж, ааШлуулж ирэв.*

ААШЛУУР өрөм, тос, тараг мэтийг нухах, хорших зэвсэг.

ААШТАЙ ааль авир муутай; *аштай морь; олон аштай хүн.*

АБСОЛЮТ үнэмлэхүй, туйлын.

АВ I эцэг.

АВ II анг хомроглон агнах; **ав тавих** (авын төвөөс гарлаж нэг нэгээр хоёр тийш илгээх); **ав тарах** (ав хоёр тийшээ хагалан одох); **ав хураах** (ав төгсч од нь, хоёр зах тийшээ салж, хойш одох); **авын төв** (авлан хомрого тавихад гар, одыг анх үүсгэн гаргах газар); **авын сүвээ** (авын төвийн дараа хоёр этгээдэд байгч нь); **авын гар** (авын хоёр сүвээний дараа явагчид); **авын од** (хомрогоны хоёр үзүүр).

АВ III хүч нэмэх сул үг; *ав ариун, ав адил.*

АВ IV: **ав сав** 1. хөнгөн хуумгай; 2. бага сага, аар саар, **ав зантай** (тогтворгүй, хялбар хувирах; *нотгүй ав зантай; гэнэт догшрох ав зантай).*

АВААЛ угийн биш, авмал юм, авсан юм; *аваал эд.*

АВААЛЬ анхны холбосон эр эм; *авааль эр, авааль эм.*

АВААС байваас, бөгөөс, болбоос, бол; *эрт явахгүй аваас өдөртөө эргэж ирж чадахгүй; чи мэдсэн аваас сайн.*

АВААЧИХ 1. авч одох; *гэртээ аваачих; хол аваачих; чирж аваачих; урьж аваачих; чи над аваачиж өг;* 2. биедээ халгаах ойртуулах; *салган аваачих;* **дур зоригоор аваачих** (дур мэдэн үйлдэх); **цаазаар аваачих** (ял унаган алах).

АВАГДАХ авахын үйлдэгдэх хэв, автах.

АВАГЧ авах этгээд; **худалдан авагч** (худалдан авах этгээд); **хүлээн авагч** (цахилгаан дэн, цахилгаан халаагуур, цахилгаан хөдөлгүүр мэтийн зай хэрэглэх хэрэгсэл); **радио хүлээн авагч** (дуу, авиа, нэвтрүүлэг, дохио тэргүүтнийг хүлээн авах буюу цахилгаан эрчмийг дуу авианы эрчим болгох хэрэгсэл).

АВАД даруй, хялбар, ав авсаар, мөд; *авад дуусахгүй; авад анахгүй.*

АВАЙ I 1. эрд холбосон авхай; 2. эхнэр хүний хүндэтгэл.

АВАЙ II: **дуран авай** тусгай урт хонгионд томруулах шил тааруулж алсын бараа харах том багаж.

АВАЙ III өршөөх, сайшаах, хөөрхийлөх, аргадах, хуурмаглах зэрэгт хэрэглэх аялга; *авай авай, эвий.*

АВАЙ IV байвай; *алс хол одсон авай.*

АВАЙЛАХ хүүхэд багачуудыг хайрлан хөөрхийлөх, сайшаах, аргадах.

АВАЛДАХ 1. авахын үйлдүүлэх хэв; 2. авлалдах.

АВАЛЦАА нийц, тохироо, холбоо; *авалцаа сайтай.*

АВАЛЦААГҮЙ нийцгүй, холбоогүй, тохироогүй.

АВАЛЦААТАЙ нийц сайтай, тохироо сайтай, холбоотой.

АВАЛЦАХ 1. авцалдах; 2. авахын үйлдэлцэх хэв, *хуваан авалцах;* 3. бусад үгтэй нийлж нийлмэл үг болно; **халаа авалцах** (ээлж солилцох); **зангаа авалцах** (зангаа мэдэлцэх); **гал авалцах** (цонон шатах); **авалцан хөлдөх** (мөрөн голын ус үргэлжлэн хадаалах; олон юм барилдан хөлдөх); 4. ярина тэмцэлдэх, ноцолдох, хэрэлдэх.

АВАЛЦУУЛАХ 1. авалцахын үйлдүүлэх хэв; 2. зодолдуулах, хэрэлдүүлэх; ☆ **гал авалцуулах** (гал ноцоолгох, асаалгах); **буу авалцуулах** (бууны цэнэг үл бааруулан асаах).

АВАМГАЙ 1. авч сурсан; 2. дуулгартай, үг *авамгай.*

АВАМТГАЙ авамгай.

АВАМХАЙ 1. шунахай; 2. авамгай.

АВАНГААР хэтэрхий шунамхай, олз ашигт ханахыг мэдэхгүй хомхой.

АВАНГАРД 1. манлай, манлайлагч; 2. хушууч.

АВАНГАРДЛАХ манлайлах, хушуучлах.

АВАНХАЙ уршиг, нөлөө.

АВАНХАЙЛАГДАХ аванхайлахын үйлдэгдэх хэв, бусдын уршиг нөлөөнд татагдах, чирэгдэх.

АВАНХАЙЛАХ ямар нэгэн юм, бусад юмыг өөрийн уршиг нөлөөндөө татаж оруулах; *хаврын шинэ цас, хуучин цасаа аванхайлах; ах нь дүүгээ аванхайлах.*

АВАНХАЙЛУУЛАХ 1. аванхайлахын үйлдүүлэх хэв; 2. аванхайлагдах.

АВАХ 1. юмыг өөрийн болгох; *би авъя; ажилд авах;* **эхнэр авах** (гэрлэх); **хүүхэд авах** (үрчлэх): **түрүү авах** (наадамд морь нь түрүүлэх); **тарга авах** (мал таргалах); **үг авах** (а. дуулгартай байх; б. үг алдуулах); 2. зэрэгцэх; хам нөхцөл үйл үгтэй нийлэн авахын

утга гарна; *сонгож авах; хувааж авах; сорж авах; завдаж авах; алдсан юмаа олж авах; иэдэхгүй юмаа мэдэж авах; сурч авах; худалдан авах; булаан авах; эзлэн авах;* 3. зэрэгцэх нөхцөл үйл үгтэй нийлэн, тавтай удаан гүйцэтгэх байдлыг үзүүлнэ; *тэнд очоод хэвтэж авлаа; санасныа хэлж авлаа;* 4. урьдчилах нөхцөл үйл үгтэй нийлэн, нэгэнтээ үйлдэн турших гэсэн санааг гаргана; *цохиод авах; уншаад авах;* 5. биенд ямар нэг согог суух; *нуруугаа авах; зоогоо авах;* 6. бус үгтэй нийлэн ямар нэг бодол төрхийг үзүүлнэ; *ажиг авах; сэжиг авах; хар авах; санаа авах;* 7. зарим хувцас хэрэглэлийг тайлах; *малгай авах; бээлий авах;* 8. биенээс салгах; *ус авах; хумс авах; эмээл авах;* 9. гарахын тийн ялгалт үгтэй нийлэн, эхлэхийн утга илэрхийлнэ; *өглөөнөөс аваад орой болтол хичээллэв;* ☆ **авах аргагүй** (а. хэрэггүй, дэмий; б. авах бололцоогүй); **авах танаггүй** (авах хэрэглэх аргагүй, хэрэгцээгүй, дэмий; *авах танаггүй туранхай мал; өмссөн хувцас нь авах танаггүй болжээ);* **авч орхих** (а. тогтворгүй ааштай хүний нэгэн суурин дээр сайн муу зан хольцон гаргах; *авч орхисон зантай амьтан шүү;* б. юмны дотроос хэрэгтэй, хэрэггүйг үзэж ялгах); **ам авах** (зөвшөөрсөн, хүлээсэн үг гаргуулах, дахин няцахгүй гэж ягштал хэлүүлэх); **ам хэл авах** (батлах үг гаргуулах); **амь авах** (а. амийг аврах; б. амийг таслах); **анир авах** (амьтан бусдын чимээг сэрэх, чимээ авах ч гэнэ); **газар авах** (лавширах, өвчин ужиж хүндрэх); **гэрэл авах** (гэрэл үзүүлэхийг цээрлэх зүйлд осолдож гэрэл үзүүлэх); **зураг авах** (гэрэл зургаар дүрсийг гаргах); **зүлд авах** (анд хамт явсан буюу замд тохиолдсон хүмүүс, алсан тураг ангийн махнаас оногдох хувь хүртэлцэх); **зүрх авах** (урьд ихэд айснаас болж хожим бэрхшээх болох); **идэш авах** (хүйтний улиралд идэхэд бэлтгэж мал нядлах); **идээ авах** (сүүн шимээр хүнс идээ боловсруулан хураах); **нойр авах** (дутагдсан нойрыг нөхөж ханатал унтах); **ус авах** (а. усны аюулд учирч тохиолдох; б. ус зөөж авчрах; в. эмчлэх буюу шинжлэх зорилгоор ямар нэгэн эрхтэнд тогтсон усыг гаргах; *нугасны ус авах; уушигний ус авах);* **салхи авах** (а. салхи цохихыг цээрлэх зүйл. салхинд үлээгдэх, салхинд цохигдох, хөлс сэвэх ч гэнэ; б. ан амьтан салхинар үнэр авах); **өл авах** (идэш хоолны зүйлийг зөвхөн идэж цадах); **үнэр авах** (ан амьтан салхины дээд талаас ирсэн бусдын үнэрийг сэрэх); **хайр авах** (бусдад дотнологдон хайрлагдахад хүрэх); **хал авах** (бусдын хэлсэн зөвлөсөн үг сургамжид атгаг санах); **хулгай авах** (хулгайд алдах, хулгайчийн гарт орох); **хүлээн авах** (а. зочид гийчнийг хүндэтгэн зориуд учирч танилцах; б. дуу, авиа, нэвтрүүлэг, дохио зэргийг хүлээн авагчаар сонсох); **хүч авах** (а. тарга авах; б. бусдын хүчинд шүтэх; в. чадал эрч нь нэмэгдэх); **хэл авах** (бусдаас хариу үг чимээ лавлан мэдэх); **чийг авах** (юм нойтон мэт болох); **шан авах, шагнал авах** (хийсэн бүтээсэн үйл ажлы нь үнэлэн бодож олгосон шагнал хүртэх); **ширээ авах** (үйлчилгээний газраас тусгай ширээнд бэлтгэсэн идэш уушийн зүйлийг худалдан авч хэрэглэх); **төл авах** (малын төл бойжуулах); **ургац авах** (хадлан тарналан хураах); **арга хэмжээ авах** (а. зэмлэл хүлээлгэх; б. шаардлагат асуудлыг шийдвэрлэх); **зээл авах** (эд мөнгө хожим төлөхөөр урьдчилан хэрэглэх); **цох авах** (тоглож, цохон дээр няслах); **шав авах** (тоглож бугуй дээр хоёр хуруугаар шавхуурдах); **хар авах** (учрыг бүр түр мэдэж хардах); **мэдээ авах** (а. бүртгэл дүн тодорхойлолт авах; б. сураг чимээ сонсох); **нэр авах, цол авах, зэрэг авах** (тусгайлан оноосон нэр, зэрэг, цолтой болох). ᠠᠪᠬᠤ

АВАХУУЛАХ 1. авахын үйлдүүлэх хэв; 2. авагдах; 3. амьтны ур зулзагыг өөр эхтэй болгох; *хурга авахуулах; тугал авахуулах;* 4. автах, дийлдэх. ᠠᠪᠤᠯᠤᠭᠤᠯᠬᠤ

АВГА I эцгийн талын төрлийн ахмад хүмүүс; *өвөг авга; авга ах; авга эгч.* ᠠᠪᠤᠭᠠ

АВГА II өвөр монголын нэгэн аймаг, *авга хошуу.*

АВГА III ургамал иш шудраг, навч дүгрэг, маш илбэруу, хатуурахын урьд навчийг авч холимог хийж идэх ногоо. ᠠᠪᠤᠭᠠ

АВГА IV зурхай тэнгэрийн бүслүүрт орших Өдлын хэнгэрэг гэдэг гялгар одоор голлосон оддын ордын нэр.

АВГАЙ I гуай, ах настныг хүндэтгэх үг, хүний нэрийн дараа хэлнэ. ᠠᠪᠤᠭᠠᠢ

АВГАЙ II 1. настай эхнэр, чавганц; 2. гэргий. ᠠᠪᠤᠭᠠᠢ

АВГАЙЛАХ гуайлах. ᠠᠪᠤᠭᠠᠢᠯᠠᠬᠤ

АВГАЛДАЙ I амьтан өт, шавьж аалз, хавч, хөөр нутагтан амьтны үрс, уул амьтдын хөгжлийн анхан шатны үед байгаа учир нас бие гүйцсэн үеэсээ эрс ялгаатай. ᠠᠪᠤᠭᠠᠯᠳᠠᠢ

АВГАЛДАЙ II бөөгийн онгод сахиусны дүрст хүүхэлдэй буюу баг.

АВГАНАР өвөр монголын нэгэн аймгийн нэр; *зүүн баруун авга нар.* ᠠᠪᠤᠭᠠᠨᠠᠷ

АВДАР хайрцгаас том, дөрвөлжин хэлбэртэй, дээрээ буюу урдаа нээлхий хавхагтай, эд юм агуулах, гэрийн хогшил сав; *айлаас эрэхээр авдрандаа эр зүйр;* **авдран сэвэг** (бургас мэтээр сүлжсэн юм агуулах сав). ᠠᠪᠳᠠᠷ

АВДАРЛАХ 1. юм хумыг авдар дотор агуулах; 2. з ү й р л э с э н эд хөрөнгийг хуримтлуулж хураах; *тэднийх хөрөнгөө авдарласан айл.*

АВЗААЛАХ оморхог, хөөрхөг, элдэв зан ааль гаргах.

АВЗААТАЙ оморхог, хөөрхөг, элдэв зан аальтай.

АВИА 1. сонсголын эрхтэнд хуран мэдэгдэх аргаар буюу бусад орчны өчүүхэн хэсгийн хурдныа хэлбэлзэх хөдөлгөөн; 2. хүний хэлэх үгийн үе хувиарт мах бод; *эгшиг авиа; гийгүүлэгч авиа; авианы тогтолцоо.*

АВИАЗҮЙ хэлний шинжлэлийн нэгэн салбар; 1. авианы байгууллыг судлах ухаан; 2. хэлний авианы байгуулал, бүрэлдэхүүн.

АВИДАРМА танин мэдэхийн зарчим хийгээд орчлон ертөнцийн мөн чанар огоот үл хувирахыг номлосон идеалист сургаал.

АВИЗИЙ з у р х а й Матрын ордын таван одны нэр.

АВИР I зан ааль, аашлах байдал

АВИР II: **авир шивэр** сэм яриа; *авир шивэр ярих; авир шивэр хэлэлцэх.*

АВИРАМТГАЙ авирахдаа дуртай.

АВИРАХ өндөр юм өөд мацалхилан гарах, асаж гарах; *өөдөө авирах.*

АВИРГҮЙ ааштай, зан муутай.

АВИРГҮЙДЭХ хэтэрхий авиргүй байдал гаргах.

АВИРГҮЙТЭХ зүйгүй зан байдал гаргах, дүрсгүйтэх.

АВИРЛАХ элдэв авир зан гаргах.

АВИРМААР авирахад аятайхан.

АВИРТАЙ зан ааш муутай, авир ихтэй.

АВИРУУШТАЙ авирмаар.

АВИШИГ х у у ч и р с а н 1. рашаанаар угаах, ус шүрших; 2. хааныг ширээнд суухад ариутган угаах рашаан ус: **авишиг олох** (а. ариутган угаалгах; б. хаан ширээнд суух); **авишиг өгөх** (а. ариутган угаах; б. хаан ширээнд суулгах, хааныг ширээнд суулгахын өмнө рашаанаар угаах буюу магнайд нь энгэсэг тавих зан үйл).

АВЛАГА бусдаас авах авцаа; **өр авлага, өглөг авлага** х о р ш.; ☆ **гарын авлага** (аливаа ажилд удирдлага болгох заавар зөвлөлгөө буюу сурах бичгийн зүйл; *багш нарын гарын авлага; тариалангийн ажилчдын гарын авлага).*

АВЛАЛДАХ 1. хэтэрхий муудалцаж бие биеэ үзэж чадахгүй дэмий татлалцан тэмцэлдэх; 2. авлахын үйлдэлдэх хэв.

АВЛАЛЦАХ 1. хэгжүүрхэн өдөөлцөж харилцан жанчилдан цуугих, мөн түүнд оролцон туслалцах; 2. авлахын үйлдэлцэх хэв.

АВЛАХ I нэгдэж хомроголон ан хийх; **агнах авлах** х о р ш.

АВЛАХ II бусдын гэм дутагдлыг эрэн хайж явах.

АВЛИГА ёсон бусаар шунаж авсан эд юм.

АВИЛГАЛАХ 1. эдэд шунах, ёсон бус аргаар юмыг олзолж авах; 2. хээл хахууль авах.

АВИЛГАЧ авлигалдаг хүн.

АВРАГА 1. бөхийн дээд зэргийн цол, улсын наадамд түрүүлсэн арслан цолтой бөхөд олгоно; **дархан аврага** (гурван удаа түрүүлсэн аврага): 2. аймаг, хот, улсын биеийн тамирын зэрэг тусгай тэмцээнд түрүүлэгч хүн буюу нийгэмлэг ,баг; *цанын аврага;* 3. бие том хүч чадалт хүн амьтан; **аврага хүн** (том бие хүн); **аврага загас** (далайн махчин том загас); **аврага могой** (халуун орны хоргүй махчин том могой); **аврага нохой** (том бие нохой); 4. аливаа асар том хэмжээ цараат юм; **аврага хөрөө** (том хөрөө); **аврага од** (их гэрэл гийгүүлэх од); **аврага сар** (Санчир гаргийг тойрсон есөн гаргийн хамгийн том од).

АВРАГАДАХ бардаагаар чадах, дийлэх, давах.

АВРАГАЛАХ аврага байдал гаргах.

АВРАГДАХ аврахын үйлдүүлэх хэв, аврах үйлд өртөх.

АВРАГЧ аврах этгээд, авардаг юм.

АВРАЙ у р г а м а л дулаан оронд ургадаг, гонзгойвтор бөөрөнхий хэлбэртэй, бор хүрэвтэр хальстай нэг зүйл үр, эмнэлэгт хэрэглэнэ.

АВРАЛ 1. өршөөн үзэж хүртэх тус; 2. үхэх сөнөх зэргийн аюулаас гаргах үйл, *зовлонгоос салахын аврал байна уу?*

АВРАЛТ аврал бүхий; *авралт гэгээн засаг.*

АВРАЛТАЙ 1. аврал бүхий; 2. аварвал зохих.

АВРАХ 1. элдэв аюулаас хэлтрүүлэх; *амь аврах; зовлонгоос авран гаргах;* **аврах бүс** (усанд унасан хүнд хаяж өгөх тусгай хэрэглэл); **аврах онгоц** (усаар зорчигчдод түргэн туслах онгоц завь); 2. дээрээс өршөөн үзэж доош хүргэн туслах; **аврах амьтан** (алах зовоох мэтээс хэлтрүүлэн тавих амьтан).

АВРУУЛАХ 1. аврахын үйлдүүлэх хэв; 2. аврагдах.

АВРАГАС хүн бусын хүчтэй, асар том биет үлгэр домгийн амьтан.

АВС хүүр агуулан оршуулах хайрцаг.

АВСААР 1. авад; *ав авсаар хийж чадахгүй;* 2. хөнгөн, хялбар, цомхон, овор бага; *авсаархан хайрцаг.*

АВСААРГА авсаар, цомхон хөнгөн.

АВСААРГАЛАХ авсаарга болгох

АВСААРДАХ хэтэрхий авсаар болох.

АВСААРЛАХ авсаар болгох.

АВСААРХАН цомхон, эвтэйхэн.

АВСЛАГДАХ авслахын үйлдэгдэх хэв.

АВСЛАХ авсанд хийх.

АВСЛУУЛАХ 1. авслахын үйлдүүлэх хэв; 2. авслагдах.

АВТАГДАХ автахын үйлдэгдэх хэв; *өргөс автагдахгүй байна; хүчинд автагдах; усанд автагдах.*

АВТАГДАХГҮЙ автахгүй, дийлдэхгүй.

АВТАСХИЙХ автахын хоромхон болох байдал.

АВТАХ 1. үүртэх, гартах, дийлдэх, эрхэнд орох; *ажилдаа автах; нөлөөнд автах; зудад автах;* 2. усны агиран хөлдөх; *гол автав; худаг автах.*

АВТАХГҮЙ дийлдэхгүй, ховхрохгүй, чадагдахгүй.

АВТО автомашин, автомобиль; *авто тээвэр.*

АВТОБАЗ авто машин агуулах засах, сэлбэг хэрэгслийг хадгалах газар; *шинжилгээний ангийн автобаз.*

АВТОБУС хүн тээхэд зориулсан олон суудал бүхий бүтүү автомашин.

АВТОГАРАШ автомашин агуулах газар.

АВТОМАТ өөрөө хөдлөх, ажиллах хэрэгсэл; *автомат станци; автомат дохио; автомат буу.*

АВТОМАТЧ 1. автомат хэрэгслээр ажиллагч; 2. автомат буугаар буудагч.

АВТОМАТЧИЛАХ автомат ажиллагаатай болгох; *үйлдвэрийг автоматчилах.*

АВТОМАШИН хүн, ачаа тээвэрлэх тэрэг; *автомашины үйлдвэр.*

АВТОМЕХАНИКЧ автомашин сэлбэн засагч.

АВТОНОМИ өөртөө засах эрх.

АВТОНОМИТ өөртөө засах, эрхтэй; *автономит улс; автономит муж; автономит засаг.*

АВУУЛАХ 1. авахын үйлдүүлэх хэв; 2. авах үйлэнд өртөх.

АВУУРЬД үргэлжид, хэзээд.

АВХААЛЖ юмыг ойлгох ,санах хийх, үйлдэх зэрэгт сэргэлэн адангатай; *авхаалж сайтай; авхаалж муутай; авхаалж нь сэргэх.*

АВХААЛЖГҮЙ сэхээ самбаагүй.

АВХААЛЖЛАХ авхаалж гаргах.

АВХААЛЖТАЙ сэхээтэй, самбаатай, золбоотой.

АВХАЙ 1. аливаа язгуртан хүний охин; 2. хаяа залуу хүүхэн, охиныг егөхөд хэлнэ; *эрхэм авхайн ааш нь хөдөлжээ.*

АВЦАА 1. бусдаас авах өр; 2. нийц холбоо; **авцаа сайтай** (нийцтэй).

АВЦАЛДАА тохиролцоо, хэлэлцээ, барьцалдаа.

АВЦАЛДААГҮЙ тохиролцоогүй, зохицолдоогүй.

АВЦАЛДАХ 1. хооронд нь нийлэн барилдах; *авцалдан хөлдөх; авцалдан наалдах;* 2. харилцан хэрэлдэх, ноцолдох; 3. харилцан тохирон зохилдох; *ярих нь авцахдаж байв.*

АВЦАЛДУУЛАХ авцалдахын үйлдүүлэх хэв.

АВЦАХ нийлэх, тохирох, ойртох; *ажил онол нь авцах.*

АВЦАХГҮЙ хоорондоо нийлэхгүй, авцалдахгүй, тохирохгүй.

АВЦГААХ 1. авахын олноороо үйлдэх; 2. зүйгүй эд авлигалах, хахууль авах, ☆ **авцгаах бичиг** (алба сангийн юмыг авах учир баримт тэмдэг болгох бичиг)

АВЧ боловч; *сурсан нь их авч дадлага бага.*

АВЧИН авд гарагсад; **анчин авчин** х о р ш.

АВЧИХ I агчих, агших.

АВЧИХ II авч орхих; *хулгай авчих.*

АВЧРАХ авч ирэх; *хоршооноос гурил авчрах; гаднаас түлээ авчрах.*

АВЧРУУЛАХ авчрахын үйлдүүлэх хэв.

АВЬСАН ахын эхнэр, дүүгийн эхнэрийн авьсан болно; **авьсан ажин** (ах дүү хоёрын эхнэр харилцан бие биеэнйг нйнхүү дуудна).

АВЬЯАС 1. төрөлхийн хүсэл дуршил; 2. аливаа юмыг бүрэн хийж чадах чадвар; *авьяастай жүжигч; хийсэн юмандаа авьяастай;* **авьяас чадвар, авьяас билиг** х о р ш.

АВЬЯАСАРХАГ авьяас сайтай.

АВЬЯАСАРХУУ авьяасархаг.

АВЬЯАСГҮЙ дур сонирхолгүй, эв дүйгүй.

АВЬЯАСЖИХ авьяас авхаалж нь улам сэргэж нэмэгдэх.

АВЬЯАСЛАГ авьяас сайтай.

АВЬЯАСЛАХ авьяас нь илрэн гарах, авьяасаа гаргах.

АВЬЯАСТАЙ авьяас ихтэй, дуршилтай, сонирхолтой, оролдлоготой.

АВЬЯАСТАЙВТАР нилээд авьяастай.

АГ I 1. чанга, барим, давчуу, явцуу; *зодог нь аг барьчихсан байв;* 2. наалдан хатах мэтээр авцалдан барилдах; *аг барилдан хөлдөх.*

АГ II: **аг чиг** чимээ аниргүй байдал, **аг чиг** болох (сураг чимээгүй болох).

АГ III цэцэг өвчний туурснаас хувилж эдгэрээгүй үлдсэн уг; *цэцэгтсэнээс үлдсэн аг.*

АГ IV цагаан; *аг цагаан сахалтай* (үлгэр).

АГАА 1. ураг төрлийн доторхи нас ах эрэгтэй хүнийг хүндэтгэн нэрийг цээрлэж нйнхүү дуудна; 2. урьдын цагт эхнэр хүнийг хүндэтгэн нйнхүү дуудаж байсан.

АГААЛЬ 1. олон даяар заншсан суртал; **агааль суртал, агаал заншил** х о р ш.; 2. хүмүүсийн энгийн дуулан гингэнэх зан.

АГААР 1. хийн мандлыг бүрэлдүүлдэг азот, хүчил төрөгч зэрэг хий; *амьтан ургамал агааргүй амьдарч үл чадна; цэвэр агаарт явах; ус агаар мэт чухал (их чухал);* ☆ **агаар эмнэлэг** (нарны гэрэл илч дулаан агаараар эмчлэх эмнэлэг); **агаарын зам** (нисэх онгоцоор зорчих зам); **агаарын мэдээ** (агаарын цахилгаан мэдээ, утасгүй цахилгаан мэдээ); **агаарын цэрэг** (нисэх хүчний цэрэг); **агаарын байлдаан** (агаарт байлдах байлдаан); **агаарын тээвэр** (нисэх онгоцоор тээх тээвэр); **агаарын шуудан** (онгоцоор илгээх шуудан); 2. аливаа дүрст бодис үүдэх оршихуйд үл торох тулах зай, огторгуй; **хоосон агаар** (огторгуйн хоосон); **хий агаар** (агаар огторгуй); 3. аливаа орон багтаамж; **номын агаар** (шажин ном дэлгэрэн түгэх орон); 4. уг чанар мөн чанар, эх үүсгэл, гүн, **сэтгэлийн агаар** (сэтгэгэлийн уг, сэтгэлийн гүн); *Хол ойроос хулгай хийх хүн хийгээд Хотыг эргэн гэтэх чоно хоёрын Ахуй бие дур ангид боловч Авах идэхийг хүсэх сэтгэлийн агаар нэгэн буй.* (Цогт тайжийн чулууны бичгээс); 5. дэлхийн хийн мандлыг бүрэлдүүлэх нарийн бүтэцтэй бодис; **агаарын хугарал** (дэлхийн агаар мандал дахь гэрлийн хугарлаас нөлөөлж тэнгэрийн бодис үймрэн харагдах байдал); **агаарын хуурай багана** (гаднах даралтад шахагдан нягцуурч агшин зуур дулаан үл нэвчих чанар олсон хуурай хий); **агаарын тундас** (бороо, цас, мөндөр); **агаарын хийн даралт** (агаар мандлын даралт); **агаарын хийн урсгал** (халуун хүйтний шалтгаанаар агаарын даралт газар бүр нягт сийрэг харилцан адилгүйн улмаас нягт газраас сийрэг тийш хийн урсах үзэгдэл буюу салхи гарах); **агаарын үнэмлэхүй чийг** (нэг шоо дөрвөлжин метр агаарт оршиж буй усны уурыг граммаар хэмжсэн тоо чанар); **агаарын харьцахүй чийг** (агаарт хурах чийгийн байдлыг халуун хүйтний нөхцөлд хамааруулан хэмжих чанар); **агаарын давхрага** (газрын дээрх шим мандал, давхрага мандал, цэнэгт

мандал гэж хуваах агаар мандлын давхрага); **агаар мандал, агаар бүрхүүл** (дэлхийн гадаргууг бүрхэж, буй агаар хийн бүрхүүл); **агаарын сонсгол зүй** (түгээмэл агаар мандалд дуу авиа түгэн тархахуйг судлах зүй); **агаарын хараа зүй** (агаарт гэрэл сарних, шингэх, хугарах, ойх, цацрах тэргүүтэн агаар мандлын үзэгдлийг судлах зүй); **агаар мандлын цахилгаанлиг** (агаар мандалд гарах элдэв цахилгаан үзэгдлийн цогц); **агаарын даралтын хэмжүүр** (нэг хавтгай дөрвөлжин см. талбайд 1,033 кг. жингээр дарахуйтай тэнцэх хийн бодисын даралтыг хэмжих нэгж); ☆ **агаараас** (а. нотод баримталсан санааны үүднээс хийх үйл; *эцэг эх нь үр хүүхдээ сайн болгох санааны агаараас элдвээр сургамжилна;* б. огторгуйн уудмаас хэмээх утга; *огторгуйн агаараас үүл ургаж хур бууна).*

АГААРАХ гаарах, дэндэх, улам хэтрэмхийлэх.

АГА з у р х а й Нумны оддын нэгэн од.

АГАРМАГ аргамаг, ажнай.

АГАЛИГ: агалиг алим гүйлсний мод мэт цэх модонд ургадаг, хальс өнгө нь алмарад жимсний адил, хурц хүчтэйхэн амттай жимс.

АГАР бараг бөөрөнхий, том том шогшгойтой, хайрслаг шилмүүстэй, сайхан үнэр анхилмал, **мөнх ногоон** мод буюу бут.

АГАРУУ том модон хувин, хавчиг; *агаруу дүүрэн айраг; усны агаруу.*

АГАЧ: агач тахиа үүлдэр муу тахиа.

АГВУУСВАА у р г а м а л энэтхэг газрын жимс, янз дүн гуа мэт том, болсон хойноо хүрэн өнгөтэй, хагалбал дотроо тахианы өндөг шиг арван жимс гардаг, ховхолж идэхэд адбиш амттайхан.

АГДАГА: агдага агдага хийх агдагар юмны үргэлжлэн хөдлөх.

АГДАГНАХ 1. агдагар юмны агдага агдага хийх; 2. хагдаганан, тэчъядан инээх; *агдаганан хагдаганан инээх.*

АГДАЙЛГАХ агдайхын үйлдүүлэх хэв, агдагар болгох.

АГДАЙХ агшиж богино охор болох, агдагар болох, агдагар байх.

АГДАЛЗАХ 1. хорхой шавьж зэргийн байн байн агдайх сунах; 2. агдгар юмны агдас агдас хийх.

АГДАРГАНА у р г а м а л сонгинын төрлийн олон наст том нэцэгтэй ургамал, дотроо-төрөл зүйл олон.

АГДАС: агдас агдас хийх агдагар юмны байн байн хөдлөх.

АГДАСХИЙХ 1. цочих, даарах, өвдөх мэтэд дав хийж хөдлөх; 2. унасан морь малын амыг татахад гэнэт зогсох; *агдасхийн зогсох.*

АГДГАЛЗАХ 1. хорхой шавьжийн атрин сунан алгууруар хөдлөх; 2. агдалзах.

АГДГАР богино, тагдгар атигар.

АГДЛАХ I уях, хүлэх, хорих зэргээр бэхлэн хадгалах; *агдлан уях, агдлан хорих.*

АГДЛАХ II хүчнээс хэтдэх овор их буюу хүнд нүсэр юмыг барин тавин ажиллаж болохгүй байх; *том юм өргөхөд бие агдлаад хэцүү байдаг.*

АГДЛУУЛАХ агдлахын үйлдүүлэх хэв.

АГЕНТ албан байгууллагын үүрэг даалгаврыг биелүүлэх төлөөлөгч, үйлчлэгч хүн; *худалдааны агент.*

АГЕНТЛАГ 1. төв байгууллагын салбар; *санхүүгийн агентлаг;* 2. гадаад дотоодын мэдээ солилцох албан газар; *Монголын цахилгаан мэдээний агентлаг.*

АГЗАГА: агзага агзага хийх агзгар юмны үргэлжлэн хөдлөх.

АГЗАЙЛГАХ агзайхын үйлдүүлэх хэв.

АГЗАЙХ 1. агзгар болох, агзгар байх; 2. даарч жихүүцэн бие аягүй болох; *бие агзайгаад байна, халуурах нь бололтой.*

АГЗАЛЗАХ агзгар юмны агзас агзас хөдлөх.

АГЗАС: агзас агзас хийх агзгар юмны байн байн хөдлөх.

АГЗАМ төмөр тавихгүй үүсгэрийн үзүүрийг бонхгор болгон хийсэн харвах зэвсэг.

АГЗАМЛАХ агзмаар харвах.

АГЗГАНАХ агзгар юмны агзага агзага хийх.

АГЗГАР бие богино, агдгар, дэзгэр.

АГИРАМ ус чийгтэй буюу уян зөөлөн юмны дангинатай хадаалан хөлдөх байдал; **агирам агирам хорш..**

АГИРАХ ус чийгтэй буюу уян зөөлөн юмны дангинатал хөлдөж хадаалах; *агиран хөлдөх;* **ус агирах** (усны доод газартаа тултал хадаалан хөлдөх).

АГИРУУЛАХ агирахын үйлдүүлэх хэв.

АГИХ мөс агиран хөлдөж овойх; *мөс агих.*

АГЛАГ 1. зэлүүд, буйд; **аглаг ой** (хүн явах зорчих нь ховор ой); 2. алс хол: **аглаг хол** х о р ш..

АГЛАГА төрлийн үе сунжирч холдсон нь; *үе аглага болсон төрөл;* **аглаг далан** (голын усны хальж бялхахаас сэргийлж холхон зайтай хийсэн далан).

АГЛАГАЛАХ төрлийн үе сунжирч холдох;

АГЛАГАШИХ аглагын шинжтэй болох; *төрөл аглагаших.*

АГЛАГДАХ хэтэрхий аглаг болох, холдох.

АГЛАГЛАХ аглаг газар гарах, явах.

АГЛАГАЧ аглагт сууж бясалгал үйлдэх хүн.

АГЛАГЧ: аглагч шувуу а м ь т а н арын чандарт хар бидэр усны ар мэт ургасан цагаан шувуу.

АГЛИ харгай модны турснаас ургасан бэх, ур ч гэдэг, ардын эмнэлэгт дотрын өвчнийг анагаахад тустай, бас морь малын дайранд тавихад сайн гэнэ.

АГЛИУДАХ хэтэрхий аглиун болох.

АГЛИУН агшуун, өтгөн.

АГЛИУРАХ аглиун болох, өтгөрөх.

АГЛИУСАХ улам аглиун болох.

АГНАХ 1. ан гөрөө хийх; 2. з ү й р л э с э н өө сэв эрэлхийлэн ажих.

АГНУУЛАХ агнахын үйлдүүлэх хэв.

АГНУУР ан гөрөө; *агнуурт явах; агнуурын хэрэгсэл.*

АГНУУРЧИН анчин, гөрөөчин.

АГНУУРЬ ан хийх газар.

АГРЕГАТ цогцолбор.

АГРИМБА буддагийн шажны ёсны тарнийн аймаг номлолд мэрэгжсэн хүнд олгох зэрэг.

АГРОН у р г а м а л их төлөв хужиргүй хангай хөвд газрын уул цохионы орой хажуу мэтийн баахан хад чулуурхаг газар ургах, жижиг цагаан цэцэгтэй, нарийн иш навчтай, томруун үндэстэй, цагаан голт ургамал.

АГРОНОМ газар тариалангийн судлал.

АГРОНОМЧ газар тариалангийн судлалын-мэрэгжилтэн.

АГРОТЕХНИК хөдөө аж ахуйн ургамлыг тариалах, бордох, арчлах, хураах зэрэг арга ажиллагаа.

АГРОТЕХНИКЧ газар тариалангийн мэрэгжилтэй хүн; *сангийн аж ахуйн агротехникч*

АГРУУ у р г а м а л агдарганын төрлийн шүүслэг, урт навчис нь жад мэт шовх, иш богиновтор, олон наст ургамал, 180 зүйл бий, зарим нь модорхуу хэлбэртэй, гэр оронд тарьж ургуулж болдог, навчисны нь шүүс эмд ордог.

АГСАА бүсэнд зүүдэг, бөсөөр хийсэн жижиг сав.

АГСААХ агсахын үйлдүүлэх хэв, агсуулах.

АГСАМ 1. согтож өдүүлэх элдэв муу ааш; *агсам тавих; агсам хүн;* 2. морь малын довтлон тэмүүлэх зан; *агсан морь*

АГСАМЛАХ агсамнах.

АГСАМНАХ 1. согтож муу ааш гаргах; 2. морь малын довтлон тэмүүлэх.

АГСАН 1. ах (байх гэсэн үйлт нэрийн гүйцэд өнгөрсөн цагийн хэлбэр; **агсан ажгуу** (байсан байжээ); **дарга агсан** (а. дарга байсан; б. дарга байгаад нас барсан).

АГСАН II агсам.

АГСАН III хүү үржүүлэн бусдаас мөнгө юм зээл авах; **агсан авах** (хүүтэй зээл авах); **агсан тавих** (хүүтэй зээл өгөх); **агсан үржил** (а. хүүгээр арвитгах; б. өр шир).

АГСАРГА саадаг хоромсого уяж бүслэх бүс.

АГСАРГАХ 1. агсрахын үйлдүүлэх хэв, 2. агсрагдах.

АГСАРХАХ агсархуу зан гаргах

АГСАРХИЙЛАХ агсчих.

АГСАХ I 1. саадаг хоромсого зүүх; *зэвсэг агсах;* 2. сүүлээ дээш нь сагсайлгах; *сүүл агсах;* 3. хий өргөгдөж хөөрөх; *хуян дээш агсаад байна.*

АГСАХ II хүн амьтны бусадтай эсэргүүцэх тэмцэхэд хүчин хавсран давшлах.

АГСГА I нумны сум агуулж, бүсэнд зүүх нэг зүйл сав.

АГСГА II 1. уналганд зүдэрч бөгсөн бие хөндүүр болохы нь; 2. хүнд ажил хийж бие зүдрэн эвэрлэхий нь.

АГСГАДАА агсга II.

АГСГАДАХ 1. уналганд зүдэрч ядрах; 2. хүнд ажилд зүдэрч эвэршээх.

АГСГАНАХ агсамнах.

АГСРАЛЦАХ агсрахын үйлдэлцэх хэв.

АГСРАХ I уурлан элдэв сүр үзүүлж аашлах; *уяатай нохой агсрав.*

АГСРАХ II албан тушаал, хэргэмээс огцрох.

АГСРУУЛАХ агсрахын үйлдүүлэх хэв.

АГСУУЛАХ агсахын үйлдүүлэх хэв, агсаах.

АГСЧИХ байн байн агсрах.

АГТ I 1. агталсан морь, луус зэрэг; ☆ **агт** мэгж (төрүүлэхгүй, таргалуулахаар өндөгний үүрийг (уураг хоты нь) авсан охин гахай); 2. адуун сүрэг; *цэргийн агт; агтны даамал.*

АГТ II: **агт араа** 25 насны үеэс ургах угийн араа.

АГТ III эмээлийн дотор этгээд нурууны журмийн хөндий буюу хоёр хонхны хоорондох хэсэг.

АГТААЛАХ үүдний хоёр хацавчид хоёр гараа тэлэн хүргэх алдлах; *үүд бүү агтаал!*

АГТАЧ агт хариулах хүн.

АГТЛАХ 1. эр малын имийг авч засах; 2. эм гахайн умайн хотыг авах; 3. гол сувгийн дээгүүр мод юм дамнагдан байх.

АГУЙ газар дор буюу уул хаданд тогтсон, гадагшаа гарах амсартай их нүх, хонгил; *хадны агуй;* **агуй их ятга** (а. цуламгай заарт модоор долоон тохой урт хийж 25 чавхдас тэвхээр тулан татсан, Монголын эртний хөгжмийн зэвсэг; б. дөрвөн хөлтэй уртлаг ширээ мэт жаазанд зэс чавхдас татаж дээр нь тусгай даруул суулгаж, эгшгийг зохируулан чавхдууараар хөгжимдөх Орос ардын нэгэн зүйл ятгын нэр).

АГУУ 1. ихийн их; *агуу их; агуу тавиу; агуу өршөөл;* 2. уудам, уужим; 3. энэрэнгүй сайн санаа; *агуу санаа.*

АГУУЛАХ 1. хураан хадгалах; *бараа агуулах; сэтгэлд агуулах;* 2. халган хоргодуулах; *гэмтнийг агуулах.*

АГУУЛГА 1. үйл ажлын мөн чанар; 2. яриаяны гол санаа, сэдэв, **утга агуулга** хорш..

АГЧ I байгч, *усны ёроолд агч загас.*

АГЧ II: **агч мод** сэрүүн бүсийн оронд ургах гойд далбагар навчит мод.

АГЧААХ агчихын үйлдүүлэх хэв, авчуулах.

АГЧИХ авчиж бага болох; *үгаахад агчдаг эд.*

АГЧУУЛАХ агчаах.

АГШААЛГАХ агшаахын үйлдүүлэх хэв.

АГШААМАЛ агшаасан юм; *агшаамал тутраага.*

АГШААХ агшихын үйлдүүлэх хэв; 1. богино болгох, атриулах, агчаах; 2. агшуун болгох, өтгөн болгох; *будаа агшаах;* 3. зүйрлэсэн тархай бутархай биш, нягт бөөн болгох.

АГШИН цагийн хэм, инчдэлийн аравны нэг хувь; **агшин зуур** (маш ахар хугацаанд)

АГШИРГАНА агшрага.

АГШИРМАЛ 1. агширсан юм; 2. галд ээж эгшээсэн мах.

АГШИХ 1. богино болох, атирах, авчих, агчих; *агшиж сунах;* 2. шингэн нойтон биш, эврүүн болох; *нойтон хөрс эврэн агшив;* 3. зүйрлэсэн тархай бутархай биш, нягт бөөн болох; *хонь агшиж хотлох.*

АГШЛАГА 1. монгол бичгийн чанга үгэнд холбон орсон „га" дэвсгэр; 2. агшмал агшсан нь.

АГШРАГА I ургамал өндөр иштэй, том навчтай, саглагар цэцэгтэй, бүдүүн үндэстэй, нуга, хээр бут, ойд ургах агдаганын төрлийн олон наст өвс, хор ихтэй.

АГШРАГА II хэтэрхий түлж шарсан идэшний зүйл; *хуурга биш агшрага болжээ.*

АГШРАХ 1. агшуун болох; 2. маш мохож ундаасах; 3. шингэн юмны царцаж өтгөрөх.

АГШРУУЛАХ 1. агшрахын үйлдүүлэх хэв; 2. махыг хуурайлан галд эгшээх; 3. будааг хүйтэн усаар сойх.

АГШУУЛАХ агшихын үйлдүүлэх хэв.

АГШУУН 1. шингэн нялцгай биш, эврүүн; 2. будааны сөмсгүй, махны өөхгүй маш хуурай, идэхэд аргуун.

АГШУУРАХ агшуун болох.

АГЬ I у р г а м а л баг цэцэгтний төрлийн өвс, цагаан саарал өнгөтэй, анхилуун хурцлаг үнэртэй, урт наст ургамал, малд тэжээлтэй; **агь нудлэх** (агнийн сая ургаж хөврөн өдөх).

АГЬ II хаад ноёдын хүү.

АГИЛУУЛАХ малыг агьтай билчээрт билчээрлүүлэх; *хонь агилуулах.*

АД I. бага хүүхэд мэтийн самбаа заль, ов живтэйг гайхан хэлэх үг; *адтай хүүхэд;* 2. бусдаас онцгой, этгээд, гажууд; *адтай хашгирах; адтай инээх;* 3. муу сүг, чөтгөр; *ад нөхцөх;* **ад зэтгэр х о р ш .**; ☆ **ад үзэгдэх** (хүнд шоовдорлогдон дор үзэгдэх); **ад үзэх** (шоодон дургүйцэх, зэвүүрхэн шоовдорлох); **ад болох** (хүнийг залхааж дургүй болгох; *байн байн хэлсээр ад болов; ад шоод болох);* **ад нөхцөх** (сэтгэл оюун гажих эвдрэх, ааш зан балайран хувирах).

АДАГ I 1. шувтрах сүүл этгээд, эцэс, төгсгөл; *голын адаг; адаг сүүлд нь;* 2. з ү й р л э с э н доод зэргийн, хамгийн муу; *хүний адаг;* **адгийн муу** (хамгийн муу); ☆ **адгийн наад зах нь** (дор хаяад, зах жишээ нь).

АДАГ II: **адаг чуулган** з у р х а й тэнгэрийн умардад орших эхэн чуулган, зүүн цааз баруун хоёр ордын хооронд оршдог гурван одны орд, газрын дундад өргөргийн орон нутагт зун, намар, өвөл сайн үзэгддэг.

АДАЙР I зан муутай, бусадтай эвгүй; *адайр зан гаргах;* **адайр хэвцэг х о р ш ..**

АДАЙР II ул тоомсорлосон, оромж байр, оронцог; *манай гэр гэж нэг адайр бий;* **малын адайр** (муу хашаа).

АДАЙР III тэрэгний арлын ялуу модонд нарийн модоор сүлжин хийсэн чиг; *тэрэгний адайр.*

АДАЙРЛАХ I адайр зан гаргах, муухай зан гаргах.

АДАЙРЛАХ II хийсэн болох, оронцоглох; *би ханаа үдэх гэж адайрлаж суна;* ☆ **амь адайрлаж** (арайхан зөвхөн аж төрөх, амиа арчлах).

АДАЙРЛУУЛАХ адайрлахын үйлдүүлэх хэв.

АДАМ 1. адгуу тэвдүү; 2. ялгуум хөдөлдөг морь мал.

АДАМБАЛ у р г а м а л шар цэцэгтэй, зарим нь зургаа долоон талт цөмөөтэй, идэхэд анхандаа гашуун, сүүлдээ амттайхан, лис жимстэй адилавтар жимс.

АДАМНАХ 1. адгуу тэвдүү байдал үзүүлэх; 2. морь малын ялгуум хөдлөх.

АДАНГА I а м ь т а н нэг зүйлийн богшрого.

АДАНГА II цовоо сэргэлэн, авхаалж сайтай.

АДАНГАЛАХ 1. юмны мөн чанарыг нарийлах нягтлах; 2. хэтэрхий яаран тэвдэх.

АДАНГАТАЙ авхаалжтай, цовоо.

АДАР I 1. байшингийн дотоод дээвэр, тааз; 2. байшингийн ваар дээврийн дор тавьсан банз халх.

АДАР II: **адар зан,** хэдэр хэвцэг.

АДАРЛАХ I адар хийх.

АДАРЛАХ II адар зан ааш гаргах.

АДАРМАА 1. төвөг, хэцүү яршигтай байдал; *адармаатай зам; адармаатай цоож;* 2. башир, хэдэр зан; *адармаа гаргах.*

АДАРМААЛАХ адрах, мэддэг чаддаг зүйлээ мэдэхгүй чадахгүй гэж хэдэрлэн баширлах, адармаа гаргах.

АДАРМААТАЙ 1. төвөгтэй, бартаатай; 2. нарийн хянуур ухаан бодолтой.

АДАХ 1. нохой зэрэг амьтны шүдний хооронд яс орж тээглэгдэн ав авсаар гарахгүй болох; 2. хадуур, хянгар зэрэгт гар хөл оглогдох; *хянгарт гараа адав.*

АДБИШ 1. үнэхээр, чухамхүү, гэсэн утга; *адбиш сайхан; адбиш цэцэн;* 2. аливаа хэтийдсэнийг өгүүлэх аялга, хосгүй, ижилгүй гэсэн санаа.

АДГАХ яаран тэвдэх; *цаг нь болоогүй байхад адгах.*

АДГУУ яаруу, тэвдүү; *адгуу хүн.*

АДГУУС 1. хүнээс бусад амьтдын нэрийдсэн нэр; *адгуусан амьтан; адгуусан амьтны хүрээлэн;* 2. доромжлоход; *адгуус шиг тэнэг.*

АДИЛ харилцан ижил тэнцүү, маш ойр төстэй; *адил болох; адил хүчтэй; адил утгатай үг; адил жинтэй;* **адил шууд** (адил болоход ойртсон).

АДИЛАВТАР адил төстэй, ойролцоо.

АДИЛСАХ адил жишээ болох, ижилсэх.

АДИЛСУУЛАХ адил жишээ болгох, ижилсүүлэх.

АДИЛТАХ адилсах.

АДИЛТГАЛ жишээлэл, зүйрлэл, зэрэгцүүхэв.

АДИЛТГАХ 1. адил гэж үзэх; 2. зүйрлэх жиших, үлгэрлэх.

АДИЛТГАШГҮЙ жишиж зүйрлэж болшгүй.

АДИЛХАН яг адил, яг ижил.

АДИЛШААЛГАХ адилшаахын үйлдүүлэх лэл.

АДИЛШААХ адилхан гэж үзэх.

АДИЛШИХ адил шинжтэй болох, адил байдал орох.

АДИЛШУУЛАХ адилшихын үйлдүүлэх хэв.

АДИС шажны ёсонд тус, өршөөл, аврал, соёрхол бий гэж итгэх баримтлал; **адис ажис** (ид эрдэмтэй зүйл); **адис авах** (а. адис гуйх саная; б. лам багш бурхан шүтээн зэргээс зулай дээр адис өгөхийг гуйх; в. ямар нэг юмыг хүндэтгэн зулайд хүргэх); **адис өгөх** (шажны ёсонд мөргөх хүний зулай дээр гар, бурхан, ном хүргэх ёс).

АДИСЛАХ адистилах

АДИСЛУУЛАХ адислахын үйлдүүлэх хэв.

АДИСТИТ I 1. соёрхол, өршөөл, аврал, хишиг; 2. адис гэсэн утга.

АДИСТИТ II: адистит тавцан зурхай арслангийн ордын гурван одны нэр.

АДИСТИТЛАХ 1. шажны ёсонд юмыг ариутгах, хүчин чадал нэмүүлэх гэж итгэн тарни урьж шивших зан үйл; 2. адис өгөх.

АДЛАХ 1. өвчин хүрсэн хүн солиорох; 2. уур хилэн төрөлтэй авир зан гаргах.

АДМИРАЛ усан цэргийн дээд тушаал.

АДРАА адармаа.

АДРААТАЙ бааш ихтэй.

АДРАХ адармаалах.

АДРЕС хаяг.

АДРЕСЛАХ хаяглах, адрестай болгох.

АДРУУ өө сэв ихтэй; **адруу будруу** (түвшин бус энд тэндгүй булцуутсан).

АДРУУЛАХ адрахын үйлдүүлэх хэв.

АДРУУТАХ өө сэв ихтэй, бартаатай болох.

АДСАГА 1. туранхилан үхсэн үхэр адууны шир буюу тугал бярууны арьс; 2. дэвсгэр болгон хэрэглэх үхэр малын хатсан шир, арьс; 3. зүйрлэсэн муухай ааш; *ааш гэж адсага.*

АДТАЙ 1. авхаалжтай, цовоо сэргэлэн; *адтай хүүхэд;* 2. шургуу; *адтай шаардах.*

АДУУ (Н) битүү туурайтны нэрийтгэл нэр; 2. морь, гүү, азрага, унаагаар бүрэлдсэн сүрэг; *адуун сүрэг; нэгдлийн адуу; адуу манах; адууны хүн;* **адуу мал** хорш.; **адуун чулуу** (хээр хөндийд онцгой ургасан хэсэг бүлэг том чулуу).

АДУУЖИХ адуу олонтой болох.

АДУУЛАХ I мал, тэжээврийн амьтдыг маллах хариулах; *мал адуулах; гахай адуулах.*

АДУУЛАХ II адахын үйлдүүлэх хэв.

АДУУЛУУЛАХ адуулахын үйлдүүлэх хэв.

АДУУС адгуус.

АДУУЧ (ИН) адуу маллах хүн; *адуучин.*

АДЬЯА Ням.

АЖ I 1. „а" гэдэг дутмаг үйл үгийн зэрэгцэх төлөв; 2. амь зуух, амьдрах, хөдөлмөрлөхтэй холбоотой утга; *аж амьдрал,* **аж ах** (а. аж төрөх, б. байж байх); **аж төрөхтэй** (чинээлэг амьдарлагатай); **аж ахуй** (а. нийгэмлэгийн ямар нэг хэв хэвшлийн үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэх харьцааны бүгд цогц; *таваарын аж ахуй; нийгэм журамт аж ахуй;* б. үйлдвэрлэл, эдийн засаг, үйлдвэрлэлд хэрэглэгдэх ба түүний бүтэж бий болох бүх зүйлсийн цогц; *улс ардын аж ахуй; сангийн аж ахуй; хөдөө аж ахуй; манай хангай нутгийн ойн аж ахуй;*

загасны аж ахуйн зохион байгуулалт; хөдөө аж ахуйн нэгдлүүдийн сүү цагаан идээний аж ахуй; в. үйлдвэрлэлийн хэсэг, нэгж байгууллага; *нэгдлийн аж ахуй; хувийн аж ахуй; том аж ахуй);* **аж ахуйч** (сайн ажиллагаатай); **аж үйлдвэр** (түүхий эд боловсруулан гаргах байгууллага буюу ардын аж ахуйн салбар; *аж үйлдвэрийн комбинат; аж үйлдвэрийн хоршоолол).*

АЖ II ажээ, байжээ.

АЖАА 1. лам эцгийг цээрлэн дуудах нэр; 2. ураг төрлийн доторхи ах зах хүнийг хүндэтгэн, цээрлэн дуудах нэр.

АЖААМУУ хүсэх гуйх аялгуу; *уучлах ажаамуу; өршөөх ажаамуу.*

АЖААРАХ ажиглах болгоомжлохын хүндэтгэл.

АЖГАР бужгар; **ажгар бужгар** х о р ш..

АЖИГ I юмыг анхаарч мэдэх нь; **ажиг сэжиг** х о р ш.; *ажиг авах; ажиг мэдэх; ажиг авахуулахгүй байх;* **ажиг дарах** (тус хорыг тэмдэглэн авах).

АЖИГ II сураг, чимээ; **ажиг сураг; ажиг чимээ** х о р ш..

АЖИГГҮЙ анхааралгүй, тоомсоргүй.

АЖИГГҮЙДЭХ хэтэрхий ажиггүй байдал гаргах.

АЖИГГҮЙТЭХ ажиг муутай байх, огт ажиггүй байх.

АЖИГДАХ ажихын үйлдэгдэх хэв.

АЖИГЛАГДАХ ажиглахын үйлдэгдэх хэв.

АЖИГЛАГЧ ажиглах үүрэг бүхий хүн.

АЖИГЛАЛ ажиглах үйлийн нэр; *ажиглал хийх.*

АЖИГЛАМТГАЙ ажиглаж сурсан.

АЖИГЛАМХАЙ ажигламтгай.

АЖИГЛАХ лавлан харах, хянах; *ажиглатал нэг туулай хэвтэж байв; мөрий нь ажиглан харав.*

АЖИГЛУУЛАХ 1. ажиглахын үйлдүүлэх хэв; 2. ажиглагдах

АЖИГНАЙ зээр гөрөөс агнахад хөлий нь торгож, шөрвөс булчингий нь хэрчин шархдуулах зэвсэг.

АЖИГЧ ажиглахдаа сайн.

АЖИГЪЯАН: ажигъяан бажигъяан шагшин гайхахад хэрэглэнэ.

АЖИЛ 1. үйл, хөдөлмөр, явдал; **ажил хөдөлмөр, ажил үйл, ажил явдал, ажил төрөл** х о р ш.; *гэрийн ажил, ажил давхцах; ажил таслах, ажлын өдөр, ажлын цаг, ажлын чадвар, ажлын хөлс, бичгийн ажил, хар ажил;* **ажил хаях** (пролетари нараас эдийн засаг, улс төрийн ашиг сонирхлын үүднээс тэмцэх ангийн тэмцлийн гол хэлбэрийн нэг, үүнд хөрөнгөтнөөр ажилчны шаардлагыг биелүүлүүлэхийн тул үйлдвэр дээр ажил хийхийг зохион байгуулалттай зогсох; *нийт даяар ажил хаях; ажил хаяхыг мэдэгдэх);* 2. ямар нэг албан үйлдвэрийн газар цалин хөлс авахаар орж ажиллах нь, *ажлаас халах; ажилд авах; ажлын газар;* 3. ямар нэг зүйлийг бүтээх, боловсруулахаар явуулах ажиллагаа; *усжуулах ажил; мал маллах ажил.*

АЖИЛГҮЙ 1. ажил муутай; 2. ажил хийдэггүй; 3. арчаагүй; *ажилгүй хүн.*

АЖИЛГҮЙДЭХ хэтэрхий ажилгүй болох.

АЖИЛГҮЙТЭЛ ажилгүй болохын нэр.

АЖИЛГҮЙТЭХ ажилгүй болох хийх ажил олдохгүй болох.

АЖИЛГҮЙЧҮҮД ажил үл олдогчид.

АЖИЛДАХ ажлаар оролдох.

АЖИЛЛАГАА ажил, үйл, ажлын явц; *сайн ажиллагаа; хамтын ажиллагаа; ажиллагаа муутай; муу ажиллагаа.*

АЖИЛЛАГЧ ажил хийгч.

АЖИЛЛАРХАГ ажил сайтай.

АЖИЛЛАРХАХ ажилтайгаа гайхуулах, бахархах.

АЖИЛЛАРХУУ ажиллархаг.

АЖИЛЛАХ 1. арвитгах, сайжруулахаар оролдох; 2. ажил хийх; *чармайн ажиллах; ажиллах хүч; ажиллах боломж; ажиллах чадвар.*

АЖИЛСАГ ажилд дуртай, санаачлага оролдлого сайтай хүн.

АЖИЛСАХ ажилсаг болох, ажилсаг байдал гаргах.

АЖИЛТАЙ 1. ажил хийдэг. 2. ажил сайтай.

АЖИЛТАН голдуу оюуны хөдөлмөр хийх хүн; *эрдэм шинжилгээний ажилтан; намын ажилтан; урлагийн ажилтан.*

АЖИЛЧ 1. ажил хийж амьдрах хүн; 2. ажил үйлдвэрт шамдуу сайн; *ажилч хичээнгүй.*

АЖИЛЧИН нийгэм журамт нийгэмлэгт бол улсыг удирдах хүч бөгөөд үйлдвэрлэлийн хэрэгслийг бүх ард түмний хамт эзэмшдэг ажилчин ангид тооцогдох мэрэгшил олсон үйлдвэрийн хөдөлмөрийг хийх хүн; *заводын ажилчин; ажилчин тариачны хувьсгалт засаг; дэлхий дахины ажилчны хөдөлгөөн; ажилчны нам;* 2. капиталист нийгэмлэгт бол буржуйд дарлагдан мөлжигдсөн, үйлдвэрийн хэрэгсэлгүй, хөлсний хүн, пролетари; *ажилчин анги.*

АЖИН I дүүгийн эхнэр нь нөхрийн ахын эхнэрийн ажин болно.

АЖИН II: **ажин түжин** нам гүм, чимээ аниргүй.

АЖИНДАР нэгэн зүйл богшрого.

АЖИР: ажир нугас амьтан янз сугсар нугастай адил, маш бяцхан, мах нь нэн амттай нэг зүйл нугас.

АЖИХ ажиглах.

АЖНАЙ маш сайн морь, маш сайн хөлөг; *ажнай хөлөг.*

АЖРАХ ирэх, одох, орших, нөгцөхийн хүндэтгэл.

АЖРАХГҮЙ алзахгүй, хайхрахгүй, тоохгүй.

АЖУУЛАХ 1. ажихын үйлдүүлэх хэв; 2. ажигдах

АЖЭЭ аж гэдэг дутмаг үйл үгийн өнгөрсөн цагийн хэлбэр

АЗ зол, завшаан; **аз жаргал** хорош.; *аз болох, аз дутах; ирсний нь аз, ирээгүйгий нь хохь болов; аз нь дайрчээ; азаа үзэх; азтай охин; азаар чамтай уулзлаа; аз мэдэг; аз мэдсэн хэрэг; аз хүү ирэхэд ёоз хүүгээр цохино.*

АЗАД: азад болох ад болох, ад үзэгдэх, ирж очих, гуйх гувших нь хэтрэн, хүндгүй болох.

АЗАДЛАХ азад болгох, ад үзэх.

АЗАЙ: азай буурал цайвар буурал; *дээрээ дэн шаргал дундаа дун цагаан, доороо азай буурал* оньсого.

АЗАМ чингэх ингэх магадгүй гэж сэжиглэсэн газар хэрэглэх аялга; *чингэх азам; ингэх азам.*

АЗАР I 1. энэтхэг газрын их багш; 2. энэтхэг зан үйлд багш нарт бараалхах ёслолын үес эртний сургаалт шүлэг уншин номлогч; 3. ведийн ном судар уншигч багш; 4. их эрдэмтэн.

АЗАР II: **азар үхэр** толгойдоо сахлаг их үстэй үхэр.

АЗАР III: **бузар азар**; бузар.

АЗАРГАН: азарган цоор ургамал хээрийн ногоо, иш нь хонгилтой, борлуулж иднэ.

АЗАРГАНА ургамал зүлэг газар ургах нэгэн зүйл ургамал, навч уртлаг, захаар нь өргөс бий, үндсий нь хүн идэж болно.

АЗГҮЙ золгүй, хийморьгүй.

АЗГҮЙВТЭР баахан азгүй.

АЗГҮЙДЭХ дааич азгүй болох.

АЗГҮЙТЭХ аз дутах, завшаан үл тохиолдох.

АЗНАХ байзнах, түдгэлзэх, түр зогсголзох; *жаахан азная.*

АЗНУУЛАХ азнахын үйлдүүлэх хэв.

АЗОТ агаарын бүрэлдэхүүнд голлох өнгө, үнэргүй хий; *азот хүчил.*

АЗРАГА 1. гурван наснаас дээш, агтлаагүй эр адуу луус, илжиг; **нэг азрага адуу** (нэг азраганы хураах гүүнүүд ба түүнтэй ижилдэн явах адуу, голдуу 10—30 орчим тооны адуу байна); 2. засаагүй эр адгуус; *азарган нохой; азарган тахиа;* ☆ **азарган бороо** (түр зуурын ширүүн бороо).

АЗРАГА II 1. ханын модыг матаж залах багаж; 2. нумны гичрийн муруйг залах хэрэгсэл.

АЗРАГА III: **хонгор азрага** урьдын цагт гэмтэн хэрэгтнийг агдлан хадгалах хэрэгсэл.

АЗРАГАДАХ хана, нум зэргийг азрага багажаар засаж залах.

АЗРАГАЛАГДАХ азрагалын үйлдэгдэх хэв.

АЗРАГАЛАХ 1. азрага гүү хураах; 2. бусдыг хэтэрхий эзэрхэн ноёлох; 3. том юмны бие агдлах.

АЗРАГАЛУУЛАХ 1. азрагалахын үйлдүүлэх хэв; 2. азрагалагдах.

АЗРАГАСАХ гүү азрага хүсэх.

АЗРАГАШИХ амьтны азрагын шинж байдал үзүүлэх.

АЗТАЙ золтой, завшаантай, хийморьтой.

АЗУЙ ургамал хамар амны тамхинд хольж татах нэг зүйл өвс.

АЙ I 1. үзэгдэл, юмс, мөнхүү үзэгдэл юмсын шинж чанарын нилээдхүү ерөнхий хийсвэрлэн ангилсан төрөл зүйлийн ухагдахуун; *шалтгаан нөхцөлийн ай; тоо чанарын ай; эрэн цагийн ай;* 2. аливаа анги, хэсэг, бүлэг, зэрэг дэс; *хэл зүйн ай; үгийн ай;* 3. тус тус, анги анги, хэсэг хэсэг; **ай айгаар** (анги ангиар).

АЙ II 1. хүнийг буруушаах аялга, *ай даа; чи дээ; ай чи яваагүй юу?;* 2. гомдох шүүрс алдахад гаргах; *ай халаг!; ай хайрхан минь;* 3. сэтгэл ханах, тавлахдаа; *ай сайхан байна; ай мөн, болох нь тэр.*

АЙ III тооны үгтэй хоршиж олны шинж утгыг нэмэх; **ай түмэн** (түг түмэн, үй түмэн; *араар дүүрэн ай түмэн адуу*).

АЙВАРЛАХ 1. балмадаар ам мэдэн чалчих; 2. ажил явдлаас арга саам хийх.

АЙВАРЧ хянамж болгоомжгүй, займраач.

АЙГУУС мануухай; *айгуус босгох.*

АЙГУУТГАХ аймшигтай үг үзэгдлээр сүрдүүлэн айлгах.

АЙД санамсаргүй хэлмэхэд гарах аялга; *сочоод айд гэж хашгирав.*

АЙДАНГА 1. болгоомжлохгүй, ам мэдэн дэмий ярьдаг; 2. санаашрал хүслэн.

АЙДАНГАЛАХ 1. хянаж болгоомжлохгүй, ам мэдэн дэмий ярих; 2. айданга байдал гаргах.

АЙДАНГАРАХ айданга болох.

АЙДАНГҮЙ 1. санааны зоригоор дэмий ярих заншилтай; 2. санаашран хүсэхүй.

АЙДАНГҮЙЛАХ айдангүй зан байдал үзүүлэх.

АЙДАНГҮЙРАХ айдангүй болох.

АЙДАР догшин хэрцгий зан авир; *айдар хүн.*

АЙДАРЛАХ айдар зан байдал гаргах.

АЙДАС аймшиг; **айдас хүрэх** (урьдаас айн болгоомжилж бэрхшээх).

АЙЖУУ бага хүүхдийг айлгах аялга; *ий айжуу!.*

АЙЗААЛАХ бүдүүн тоймоор ярьж хэлэлцэх.

АЙЗАМ 1. нэгэн хүчтэй өргөлтөөс нөгөө хүчтэй өргөлт хүртлэх хэсгээр хэмжигдэх хөгжмийн аялгууны хэмжээний нэгж; **айзмын зураас** (айзмын ялгах хөгжмийн нотны богинохон босоо зураас); **айзмын үгтвар** (айзмын нэгдүгээр зураасны өмнөх нот, бүтэн айзам болохгүй); **айзмын хэм буюу хэмжээ** (айзмын байгуулалтыг тодорхойлох бутархай тоон хэмжигдэхүүн); 2. эрхэмсэг хүндэтгэлийн утга шинжит монгол ардын урт дуу; *айзам дуу.*

АЙЛ 1. нэг гэр өрх; *айл айлаас нэг хүн ирэв; айл бүрд оногдов; гурван айл нүүж явна; арван айлын орон сууц; эцэг эхээс салж тусдаа айл болов;* **айл гэр болох** (гэрлэн нийлж суух); **айл гэрийг эвдэх** (гэрлэн суугчдыг үймүүлэн салгах); 2. зэргэлдээ орших; *манайх Батынхтай айл; айл аймаг явагчид;* **айл хөрш; айл хунар; айл улс** х о р ш.; *айлынхаа айлд оров; айлын ах дүү нар; айл хэсэх; айлаас эрэхээр авдрандаа эр* з ү й р; 3. х у у ч и р с а н албаны юм хадгалах газар, албаны тариа зөөх эрчүүдийг захирах мянгатын хэрэг шийтгэх газар.

АЙЛГААЧ айлгамтгай зантай хүн.

АЙЛГАМТГАЙ айлгахдаа хялбар.

АЙЛГАМХАЙ айлгамтгай.

АЙЛГАХ 1. айхын үйлдүүлэх хэв, айн сүрдэхэд хүрүүлэх, айх сэтгэл төрүүлэх; 2. ураг төрөл дотно хүмүүс бие биестээ ямар нэгэн жижиг зүйлээс үндэслэж гомдолхилах; хүүхдийн өвдөхийг цээрлэхэд; *хүүхэд айлгаад байна.*

АЙЛГУУРЧ ураг төрөл дотно хүмүүстээ айлгамтгай тумархах зантай.

АЙЛДАЛ хүндэтгэвэл зохих хүний санаа, таалал, үг сургамж; *багшийн айлдал.*

АЙЛДАХ дээд хүмүүсийн хүндэтгэл; 1. үг хэлэх; *хариу айлдав;* 2. ажиглаж мэдэх; *баги болгоож айлдав;* 3. аливаа үйлдэх хөдлөхөд оролцуулан хэлэх үг; *мишээж айлдав; зоог-лож айлд.*

АЙЛДВАР хүндэтгэвэл зохих хүний хэлсэн үг.

АЙЛДУУЛАХ айлдахын үйлдүүлэх хэв.

АЙЛСАГ 1. айлтай байх дуртай; 2. айл хэсэхдээ дуртай.

АЙЛСАХ 1. хоёр айл нэгэн газар айл болон буух; 2. тоглоом наадмын тэмцээнд эн зэрэгцэж явах.

АЙЛТГАЛ х ү н д э т г э л, дээд хүнд сонсгох сонсгол үг бичиг; *айлтгал үг; айлтгал бичиг.*

АЙЛТГАХ хүндэтгэл, дээд хүмүүст үг хэлэх, дээд хүмүүст өргөдөл бичиг өгөх; *үг айлтгах; амрыг айлтгах; айлтгах бичиг.*

АЙЛТГУУЛАХ айлтгахын үйлдүүлэх хэв.

АЙЛТГҮЙ айх зүйлгүй, битгий ай.

АЙЛЧИН айлчлан яваа хүн; **айлчин гийчин; айлчин зочин** хорш..

АЙЛЧЛАЛ айлчлах үйлийн нэр; *төрийн айлчлал.*

АЙЛЧЛАХ 1. ураг удам, нөхөр хань зэргийн худдаа ёсолж зочлон очих; 2. зочилж очих.

АЙЛЧЛУУЛАХ айлчлахын үйлдүүлэх хэв.

АЙЛШИХ айлсаж явсаар харилцан идээших.

АЙМА́АР айж болмоор юм.

АЙМАГ 1. БНМА Улсын нутгийн засаг захиргааны том нэгж; *Увс аймаг;* 2. хүний төрөл угсаа, зан суртахуунаар нэгдсэн холбоо; *Монгол аймаг; Слав аймаг;* 3. юмыг төрөл анги болгосон хуваавар; *амьтны аймаг; ургамлын аймаг; ац тууртны аймаг; үет хөлтний аймаг; үгсийн аймаг;* 4. айлаас арай хол, саахалтаас арай ойр орших зай; **айл аймаг** хорш..

АЙМА́ГЛАЛ аймагжсан хуваарь.

АЙМАГЛАХ 1. юмыг анги төрөл, хэсэг бүлгээр аймаг болгож хуваах; 2. хүний ямар нэгэн аймагт багтаж захирагдах.

АЙМАГЛУУЛАХ аймаглахын үйлдүүлэх хэв.

АЙМАН үймэн, **айман уйман** хорш..

АЙМРААЧ аймардаг зантай.

АЙМРАХ хүний үйл явдлаас займрах ба зан ааш тогтворгүй, үг явдал шийдвэргүй болох, санаа явдал хувилж урьдад хүрэхгүй болох; **аймрах уймрах** хорш..

АЙМСАХ хилэгнэн зэвүүрхэх; *ихэд аймсан өгүүлэв.*

АЙМТГАЙ аймхай.

АЙМХАЙ эмээх, сочих, сүрдэх, халирах хялбар; *аймхай хүүхэд;* ☆ **аймхай мөгөөрс** (өвчүүний доод үзүүрийн мөгөөрс).

АЙМШИГ 1. аливаа айвал зохих зүйл; *аймшигт сүртэй;* 2. аюул хөнөөл, гамшиг зовлон учруулах юм; *аймшигт ширүүн бороо; аймшигт салхи.*

АЙМШИГГҮЙ 1. айх эмээх юмгүй; *аймшиггүй газар;* 2. эмээх, зэвүүцэх, айхыг үл мэдэх; *аймшиггүй зориг Сүхбаатар.*

АЙМШИГТАЙ зэвүүцмээр, аймаар; *аймшигтай чанга дуугарлаа; аймшигтай нохой.*

АЙРАГ голдуу сүүг хөрөнгөлөн исгэсэн унд; *гүүний айраг үхрийн айраг;* (үүнийг нэрж монгол архи гаргана); **айргийн эмнэлэг** (айргаар эмчлэх газар); ☆ **шар айраг** (арвайг нэрж гаргах бага охьтой унд); **айргийн тав** (уралдаанд түрүүлэн давхиж ирсэн таван морь).

АЙРАГДАХ 1. айраг ихээр ууж найрлах; 2. айл хэсэж айраг ууцгаах.

АЙРАГЛАГ: айраглаг жимс ойд ургадаг, иш, модны нь мөчир навч ягцуу нягт, хонгорцоглосон жимс, амт хүчтэй.

АЙРАГЛАХ 1. сүүг хөрөнгөлөн исгэх; 2. жимс ногоо зэрэг гутаж гэмтэх.

АЙРАГЧИН айраг олж уухаар хэсэж яваа хүмүүс.

АЙРГАНА ургамал улаан ягаавтар буурцаг мэт толгойтой, нарийн иштэй, гонзгор дугариг навчтай, исгэлэнхэн амттай, нэгэн зүйл ургамал, хүн иддэг.

АЙСАХ бичиг айсуй.

АЙСИХЬ: айсихь эм ардын домогт нэгэн зүйл шидтэн; эм хүний дүрстэй, сайн муу ямар ч үйлийг санааны зоргоор хийж сүйтгэж чадна гэж өгүүлдэг.

АЙСМАЛИЙ ургамал өндөр гуалиг бөгөөд өргөслөг, улаан цэцэгтэй нэг зүйл модны нэр.

АЙСУЙ юмны ирж яваа бараа нь харагдаж байгааг заана; *тэд айсуй явна; нэг машина айсуй.*

АЙХ юмнаас сүрдэх, эмээх, сочих, халирах, бэрхшээх; *айх ичихийг мэдэхгүй; айх нь эс ч аягүй юм; хийвэл бүү ай, айвал бүү хий* хууч..

АЙХАВТАР айхтар.

АЙХГҮЙ зоригтой шийдэмгий, айхыг мэдэхгүй; *айхгүй ч гэсэн аягүй;* **айхгүйгээ авдрандаа хийсэн** (айх юмгүй болсон).

АЙХТАР я р и а аймшигтай, сүрхий.

АЙШГҮЙ аймшиггүй, айх шинжгүй; *айшгүй юмнаас айх.*

АКАДЕМИ 1. шинжлэх ухааны дээд байгууллага; *Шинжлэх Ухааны Академи;* 2. зарим дээд сургуулийн нэр; *Анагаах ухааны академи; Хөдөө аж ахуйн ухааны академи; Нийемийн ухааны академи*

АКАДЕМИЧ шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн.

АККУМЛЯТОР цахилгаан, дулааны илчийг нэг дор бөөгнөрүүлэгч хэрэгсэл; зай хураагуур.

АКСИОМ илт үнэн.

АКР газрын хэмжээ; 4047 хавтгай дөрвөлжин метртэй тэнцэнэ.

АКТ албан ёсны баримт гэрчилгээ; *эмнэлгийн акт; акт тогтоох; акт гаргах.*

АКТЛАХ эд юмыг акт тогтоож данс бүртгэлээс хасах.

АКТЛУУЛАХ актлахын үйлдүүлэх хэв.

АЛ: I **ал улаан** хурц улаан.

АЛ II 1. хүний салтаа; 2. өмдний салтаа; 3. я р и а хүний бэлэг эрхтэн.

АЛ III: **ал сүүл** а м ь т а н нэгэн зүйл галуу, хээрийн галуунаас том, өрөвлөг цайвалзам цагаан, нисвэл өндөр халина, суувал ханхгар болно, алхах нь сурхий.

АЛААН хядаан, тулаан; **алаан хядаан, алаан тулаан** х о р ш . .

АЛААЧ 1. анч; 2. амьтныг үлэмж алагч.

АЛАВХИЙХ моринд харайн мордох; **алавхийх тугар** (сая сурах хүмүүсийн алавхийх модон морь).

АЛАВЦАХ тэвэг, бөмбөг мэтийг хөлөөр дэгдүүлж өшиглөх.

АЛАВЧ шуудаг өмд.

АЛАГ 1. хоёроос доошгүй өнгө холилдсон нь; **хар алаг** (хар цагаан холилдсон өнгөтэй; *алаг морь; хээр алаг морь;* 2. жигд биш, тэгш биш, янз янз; *аяганы алгаас адууны алаг нь дээр* х у у ч; **алаг булаг** (а. алагтай адил; б. зүйл зүйлийн өнгө зүс хэсэг хэсэг холилдсон); **алаг мах** (өөх мах алагласан); **алаг нүд** (яруу найрагт нүдийг магтсан); **алаг онд орох** (малын зарим нь тарган, зарим нь туранхайгаар хүйтэн улирлыг туулах); **алаг ургасан тариа** (зарим газар сайн, зарим газар муу ургасан тариа); **алаг тариалан** (зүйл зүйлийн тариаланг зурвас зурвасаар зэрэгцүүлэн тарьсан тариалан); **алаг үзэх** (дээр дор, дотно гаднын ялгаамжаатай үзэх); **алаг цоог** (хаяа хаяа, энд тэнд, хэсэг; *хадланг алаг цооггүй нийтээрээ хадав)*; **алаг мэлхий өрөх** (шагаагаар мэлхийн биеийг дүрслэн өрөөд, шоо орхиж, түүний нүхний дагуу авах, төлөх зэргээр наадна); **алаг ар** а м ь т а н (бялзуухайн нэр; нүдний цэцгий хар, зажуур шар, толгой, хүзүү, ар жигүүр цөм гялалзсан хүрэн өнгөтэй); **алаг барс** а м ь т а н (толгой цагаан, сүүл улаан, барсын бидэртэй, үянгалуу дуутай нэгэн зүйл араатан); **алаг болжмор** а м ь т а н (хар буюу хар бидэртэй, цагаан чандар холилдон ургасан болжмор); **алаг бүслүүр** а м ь т а н (хямарлаг хяруулын өөр нэр); **алаг галуу** а м ь т а н (галууны нам, чандар алагчин, Африк,Ази, Европод бий); **алаг дунгар** а м ь т а н (хушууны үзүүр матигар, хумс нь харцгайнхтай адил нэгэн зүйл бялзуухай, заримдаа бялзуухайг барьдаг); **алаг марьяа** (нэгэн зүйл өвчин, хүний нүүр гарт гарна, цагаан алаг сорви үлдэнэ); **алаг нохой** а м ь т а н (нэгэн зүйл алаг шувуу); **алаг нугас** а м ь т а н (нугасны нам, бие алаг, манай оронд үгүй); **алаг хэрээ** а м ь т а н (бие хар, хүзүүнийхээ дор гархи мэт цагаан чандартай); **алаг хуухар** а м ь т а н (өнгө алаг нэгэн зүйл шувуу); **алаг хяруул** а м ь т а н (гургуулын нам, толгой, жигүүр, сүүл хар, бидэр шар, арын чандар улаан цагаан хольцолдон ургасан, зажуурын чандар толгойг өнгөрөн ургасан нэг зүйл шувуу); **алаг толгой** а м ь т а н (толгойнхоо хойтод цагаантай, өрөвлөгийн нь дунд хар сэвхтэй шувуу); **алаг ураацай** а м ь т а н (таван зүйл өнгө бүрдсэн нэгэн зүйл хараацай); **алаг цонтуул** а м ь т а н (бие хүзүү алаг нэгэн зүйл цонтуул шувуу); **алаг нүдэн цэцэг** у р г а м а л (олон наст, өвсөрхөг ургамлын нэг зүйл; эмнэлэг, гоёл чимэглэлд хэрэглэдэг, зэрлэг таримал хоёр зүйл бий); **алаг тахь** а м ь т а н (нэг зүйл зэрлэг адуу); **алаг хулан** а м ь т а н (нэг зүйл зэрлэг адуу); **алаг шоргоолж** а м ь т а н (цээж бөгс хар, дунд бие шаравтар, нэгэн зүйл шоргоолж).

АЛАГГҮЙ ялгаварлаж үзэхгүй.

АЛАГДААГА алагдаахай.

АЛАГДААХАЙ а м ь т а н мэрэгч, хойт хоёр хөл ба сүүл урт, толгой томхон, урт сахалтай, говь, тал, хөндий газар оршино, их төлөв шөнө явдаг, өвөл ичнэ.

АЛАГДАХ алахын үйлдэгдэх хэв; бусдад **амь хорлогдох**

АЛАГЛАЛ алаглах үйлийн нэр.

АЛАГЛАЛГҮЙ алагчлалгүй.

АЛАГЛАХ 1. алаг эрээн болгох; *ясаар алагласан хашлага;* 2. алаг эрээн харагдах; *алагланхан харагдах;* 3. алагчлах.

АЛАГЛУУЛАХ алаглахын үйлдүүлэх хэв; алаг болгуулах.

АЛАГСАХ 1. алаглаж үзэгдэх; 2. юмны өнгө байдал үе үе буюу хэсэг хэсэг хувирах; 3. бусдыг ялгаварлан үзэх.

АЛАГТАЙ ялгаварлан үздэг үзэл; *алагтай булагтай; алагтай цоогтой.*

АЛАГТАХ 1. алаг болох; 2. юмны өнгө алаглан харагдах.

АЛАГТУУ амьтан хэрээний нам, бие их төлөв хар, хүзүү цагаан, сүрэглэн явж хавар түрүүлж ирээд намар буцдаг.

АЛАГЧ I 1. эм алаг; *алагч гүү; бөөр алагч үнээ;* 2. бусдыг ялгаварлан үздэг.

АЛАГЧ II алаач.

АЛАГЧИН I 1. тэгш биш, жигд биш, ялгавартай үзэх; 2. зусарч, зулгуйч.

АЛАГЧИН II амьтныг нядлагчид, хядагчид, алаачин.

АЛАГЧИН III алагч.

АЛАГЧИН IV амьтан хөвчин биедээ бүдэртэй нэгэн зүйл гоо бялзуухай.

АЛАГЧЛАЛ алагчлах үйлийн нэр.

АЛАГЧЛАЛГҮЙ бусдыг ялгаварлахгүй тэгш шударагаар үзэхийн нэр.

АЛАГЧЛАХ бусдыг дотно гадна болгож, ялгаварлан үзэх, хоёрдуулан үзэх; *алагчлах үзэл адгийн явдал.*

АЛАГЧЛУУЛАХ 1. алагчлахын үйлдүүлэх хэв; 2. алагчлагдах.

АЛАГШИХ алаг булаг болох.

АЛАЛДААН харилцан алалдан тулалдах.

АЛАЛДАХ 1. харилцан алалцах; алахын үйлдэлдэх хэв; 2. ямар нэг юмны төлөө улайн бачимдан тэмцэх; *сурахын төлөө алалдах.*

АЛАЛЦАХ 1. хамтран алах; алахын үйлдэлцэх хэв; 2. алалдах.

АЛАМ газрын их нүх.

АЛАМГАЙ үг явдал осол цалгай; *аламгай назгай хүн.*

АЛАМГАН аливаа идэх юм чандгүй буцалгаснаас улбагар усархаг болсон нь.

АЛАМГУУН холимог хоолыг идэхэд тааламжгүй болсон нь; *аламгуун шөл.*

АЛАМЛАХ газрыг алам болгон ухах.

АЛАНГИР I хөвсгөр зөөлөвтөр хөрстэй газар; *алангир хөрс.*

АЛАНГИР II тосон харгай модоор хийсэн элэгтүй нум.

АЛАХ амьтныг үхүүлэх; *чоно алах;* **алах талах** (амьтныг алан дээрэмдэх); **алах хядах** (амьтныг үй олноор алах); **алах ял** (гэмтнийг цаазаар аваачих).

АЛБА (Н) 1. улсын буюу албан газрын *ажил, үйл;* **албаны хүн** (албан хаагч); **алба хаших** (албан хаах); **албан цаг** (алба гүйцэтгэвэл зохих хэмжээт цаг); **алба залгуулах** (а. оногдсон албыг гүйцэтгэх; б. юмыг ёс төдий хуумгай хийх); **албаны хэрэг** (албаны газар эрхэлбэл зохих хэрэг); **албан ял** (албан хариуцлага алдсанд оногдсон ял шийтгэл); *улсын алба; цэргийн алба; албанд томилогдох; алба ахуй; өртөөний алба;* 2. яриа захирах тушаах журмаар заавал гүйцэтгэх үүрэг; *би заавал энд байх албатай биш; албан журмын тээвэр; тэх нь алба уу;* 3. нийтэд оногдуулан гаргах татвар; *алба авах; алба татвар; алба татах; алба гаргах;* **алба өгөх, алба барих** (өөр улсын хүн, өөрсдийн газар орноос гарах сайн эд юмыг хүргэн ирэх, бас алба өгөхийг хүндэтгэн алба барих гэдэг); **алба гувчуур** (ард олноос тэсгэн авцгаах алба татвар); **алба хугацах** (ногдол албыг хасах, хөнгөтгөх); 4. улсын хамаатай зүйл; **албаны тариалан** (а. улсаас эрхлэн байгуулсан тариалан; б. урьдын цагт зах хязгаарын цэргүүдийн үйлдэх тариалан); **албан сургууль** (улсын сангаас бүх хэрэглэгдэхүүнийг гаргаж, улсаас эрхлэн байгуулсан сургууль); *албан мэдээ; албан сэтгүүл; албан ёсны баримт;* ☆ **алба өнгөрөөх** (а. алба залгуулах; б. ажил үүргийг ор нэр болгох); **алба үглэх** (а. албан тушаалаас чөлөө гуйх; б. ногдсон албан татвар ихдэв гэж хөнгөтгөл гуйх); **албаны хувцас** (дүрэмт хувцас, сургууль цэрэг зэрэг албаны хүмүүсийн өмсөх тусгай хувцас).

АЛБАДАЛ албадах үйлийн нэр.

АЛБАДАХ хүчлэн тулгах, захиран тушаах; *албадан хөдөлмөр хийлгэх.*

АЛБАДЛАГА албадал, хавчлага.

АЛБАДЛАГАГҮЙ шаардлагагүй, хавчлагагүй.

АЛБАДУУЛАХ 1. албадахын үйлдүүлэх хэв; 2. шаардуулах; 3. албадагдах.

АЛБАТ 1. аливаа нэгэн захиргааны эрх мэдлийн дор захирагдагсад; 2. хаад, ноёд, язгууртны харьяат иргэд; *албат иргэн; албат ард;* **албат хамжлага** х о р ш.; **албат гэр** (байшингийн нурууны дагуу хийсэн үүдний пин); **албат овогт хүн** (харц хүн).

АЛБАТАН албан хаагчид; албан тушаалтан.

АЛБАЧ албан ажилд дадамгай сайн, үнэнч зүтгэлтэй шамдан ажиллагч хүн.

АЛБАЧЛАХ албан журмаар дагуулах, алба болгож журамлуулах.

АЛБИН ардын домогт нэгэн зүйл ад; **ад албин** х о р ш.; **албины гал** (чийгтэй дор газар шөнө үзэгдэх хөхөвтөр гал, амьд бодис ялзрахад үүсч ноцсон хийн гэрэл).

АЛГА I 1. гарын царвууны дотоод хавтгай тал; *гарын алга; алга таших;* **алга дарам** (өргөнөөр нэгэн алгын хир); **алгын чинээ** (тун бяцхан); **алга тосох** (гарын алгыг өөд харуулах); **алга зуузайгаа таших** (алга таших); **алга хавсрах** (хоёр алгыг нийлүүлэх); **алга хамтатгах** (алга хавсрах); 2. нэгэн гарын хуруу алга хоёрыг хонхойлгосныг дүүргэх хэмжээний нэр; *алга дүүрэн будаа;* 3. чөдрийн чагтны угын хөл ороох хавтгай хэсэг; *чөдрийн алга.*

АЛГА II үгүй, үгүй болох; *миний морь алга байв; чи яагаад алга болчихов.*

АЛГАГ I ой мод, хайр чулуу, дэрс цахилдаг зэргийн дунд байх хэсэгхэн чөлөө газар; *ойн алгаг; дэрсний алгаг.*

АЛГАГ II алгуу; **алгаг алгуу** х о р ш.; *алгаг хүн.*

АЛГАДАХ 1. гарын алгаар дэлдэх; *баавгай алгаддаг;* 2. юмыг гарын алгаар хавчин элдэж бөөрөнхийлэх, мушгих, үнгэх, ингэх; *алгадан томох; утас алгадах.*

АЛГАДУУЛАХ 1. алгадахын үйлдүүлэх хэв; *би чамайг ээжид алгадуулна шүү;* 2. алгадагдах; *хүүхэд алгадуулаад уйлав;* 3. бусдад үгээр давагдах; *аман дундууpаа алгадуулах.*

АЛГАЛАГ: алгалаг жимс у р г а м а л хос алд илүү өндөр модонд ургадаг алга шиг том жимс, амт сайхан.

АЛГАМ: алгам уужим санаа явдал саруул тодорхой, уужим тавиу.

АЛГАНА а м ь т а н алганын нам, чонон алгака, нимийн алгана, голын алгана гэх зэрэг хэдэн зүйл бий; хавчиг хавьстай, жижиг жижиг хайрстай, нуруундаа хоёр далбаатай, өнгө ногоовтор шар, нуруугаар нь хөндлөн хар журам бий; живэр далбаа улаан нэг зүйл загас; **алгана сугас** а м ь т а н (алгана хэлбэртний багийн загасны нам, тэнгис далайд орших нэгэн зүйл алгана; нуруу бие хүрэн улаан буюу хурц улаан, хэвэл нь цайвар, зураа ховилууртаа хорт булчирхай бий).

АЛГАНАГ хонины сүүлийн дотор тал, халцгай, мөн хошгиногийн орчмын халцгай газар.

АЛГАСАНГУЙ санаа огцом, самуурамтгай хүн; *алгасангуй тул үргэлж самуурна.*

АЛГАСАХ 1. даван, өнжин, алгасан өнгөрөх; *хоёр хүнийг алгасаад; гурван мөр алгасан;* 2. сэтгэл самуурах; 3. хавьталгүй өнгөрөх, өнжин өнгөрөх.

АЛГАСУУЛАХ алгасахын үйлдүүлэх хэв, алгасан өнгөрүүлэх.

АЛГАЧ өөш орхиж загас барин агнах хүн.

АЛГЕБР томьёоны ухаан; хэмжигдэхүүний чанарыг үсгээр томьёолон судлах тооны ухааны нэг салбар; *алгебрийн хичээл; алгебрийн тэгшитгэл; алгебрийн нийлбэр.*

АЛГУУ сэтгэл алгасангуй, юманд самуурамтгай, мангуу.

АЛГУУДАХ хэтэрхий алгуу болох.

АЛГУУР яаралтай бишүү, аажим; *нүдээ алгуур өргөн харав;* **алгуур аажим, алгуур аашаар, алгуур аяар** х о р ш..

АЛГУУРАХ алгуу болох.

АЛГУУРЛАХ 1. алгуур аажим болох; 2. алгасан өнгөрөх; *алгуурлан хойш тавьж үл болох зүйл.*

АЛД I хоёр гарыг хөндлөн сунгаж нэгэнтээ хэмнэсэн хэм; нэг алд нь 1 метр 60 сантиметртай тэнцэнэ; *таван алд уурга; алды нь аваад дэлмий нь* з ү й р ; **алд дэлэм** (бүтэн хагас алд 2 метр 40 сантиметртай тэнцэнэ).

АЛД II хир, үе; *үдийн алд; хоёр цагийн алд.*

АЛДАА 1. үйл явдал, бодлогын буруу; *алдаа гаргах; бичгийн алдаа засах; үг алдах;* 2. хохирол, гарз; хонжигдол; *алдаатай наймаа; мөрий алдах;* 3. осол, эндэгдэл, гэм дутагдал: **алдаа дутагдал** х о р ш.; *алдаа хүлээх.*

АЛДААГҮЙ гэм осолгүй, буруугүй, мадаггүй.

АЛДАГ: **алдаг оног** хараяа, заримдаа; *ажилдаа алдаг оног очиж байна.*

АЛДАГГҮЙ алддаггүй, хэлсэн үгэндээ, мадаггүй; *хуралд алдаггүй ирдэг хүн; алдаггүй тул түүнд итгэж болно.*

АЛДАРДАЛ алдахад хүрсэн, хохирол, алдаа, дутагдал; **алдагдал хохирол, алдагдал дутагдал** х о р ш.; *алдагдал учруулахаас болгоомжил!*

АЛДАГДАЛГҮЙ алдаагүй, хохиролгүй, гарзгүй.

АЛДАГДАЛТАЙ алдаатай, хохиролтой, гарзтай.

АЛДАГДАХ 1. алдах; 2. алдахын үйлдэгдэх хэв; **санал алдагдах** (урам хугарах).

АЛДАД орчим, үе; *удийн алдад; арван цагийн алдад.*

АЛДАЛ 1. осол, эндэгдэл, бууруудал; 2. алдсан сарнисан юм.

АЛДАМЧ аму тарианы зүйлийг хэмжих үүрэгтэй хүн; *сангийн аж ахуйн алдамч.*

АЛДАР 1. нэрийн хүндэтгэл; *таны алдар хэн бэ?; нэр алдры нь асуув;* 2. олонд тарсан, дуурьссан нэр; *алдар хүнд; алдар туультай; алдраа мандуулан; алдар нь цууриатав; алдар ихтэй; алдартай бөх; алдар нэрийг гутаах;* 3. үнэнгүй бөгөөтөл хуурам бадруулсан цуурхал.

АЛДАРТ нэрд гарсан, хүндтэй болсон; *алдарт зохиолч; алдарт нам; алдарт Монгол.*

АЛДАРТАЙ алдар бүхий, алдар ихтэй.

АЛДАРШИЛ алдарших үйлийн нэр.

АЛДАРШИХ олонд нэр гарах; цууриатах; *сайн ажилчны нэр нь алдаршина.*

АЛДАРШУУЛАХ алдаршихын үйлдүүлэх хэв.

АЛДАС 1. эндэгдэл, цалгардал; 2. шажны ёсноо хүндэтгэвэл зохих юмыг доромжилсон доромжлол; **алдас болох** (хүндэтгэвэл зохих юмыг доромжлох).

АЛДАСЛАХ алдас болох.

АЛДАХ 1. барьж байсан юмыг осолдож унагаах; *гартаа барьж явсан ташууpаа алдав;* 2. барьж, торгож, тогтоож байсан юмыг чадалгүй сул болгох; *уурга алдах;* 3. авч байлгаж байж чадахгүй болох; *сууриа алдах; морио алдаж орхив;* 4. байвал зохих ямар нэг байдал үгүй болох; **зүс алдах** (өнгө зүс гутаж муудах); **сойлго алдах** (сойвол зохих хугацаанд хүрч эс чадах); **өнгө алдах** (жинхэнэ өнгө дүр нь үгүй болох); **хүч алдах** (чадал эрч муудах); **хэмжээ алдах** (буруу хэмжих); 5. бие махбодын ялгадас цаг бусаар гарах; *шээс алдах; чацга алдах;* **хөлс алдах** (а. хөлс маш ихээр асгаран гарах; б. хөлс сэвж гэм эмгэг тохиох); 6. байсан юм, үгүй болон завхрах; *хулгайд алдах;* 7. худалдаа, үйлдвэр, түүнчлэн мөрийтэй наадах зэрэг ашиг ээрэх зүйл гарз хохирол болох; *ашиг алдах; тоглоомд алдах;* **бэл алдах** (худалдаа наймаанд хөрөнгө мөнгөө хохирох); 8. ямар нэг учраас гэнэт гарах дуу аялгуу; **дуу алдах** (баярлах сочих зэрэгт гэнэт чанга дуугарах); 9. шидэх, харвах, буудах зэрэгт үл онох; *калибраар буудаад алдаж орхижээ;* 10. үл болох юмыг осолдон хийчих; **буу алдах** (осолдон буу дуугаргах); **гал алдах** (а. галыг хамгаалан чадахгүй гэнэт түймэр шатахад хүрэх; б. түлшээр тасарч галлаж чадахгүй болох); **түймэр алдах** (осолдож гал шатахад хүргэх, гарсан түймрийг унтрааж чадахгүй өрөвсхийх); 11. эндэж бууруудах, ташаарах; *алдаа алдах;* 12. туслах үйл үгийн чанартай бөгөөд завдах, шахах бараx, үйлдэх гэдэг утгыг хадгалана; *уйлан алдах; барин алдах;* 13. бусад хэллэгт гарах нь: **ам алдах** (а. амаар зөвшөөрөх; *ам алдвал барьж болдоггүй, агт алдвал барьж болдог* з ү й р; б. тангараглах); **ажлаа алдах** (ур ашиггүй ажил оролдох, дэмий цаг өнгөрүүлэх); **чадвараа алдах** (ажиллах чадваргүй болох); **аргаа алдах** (хэрхэх аргаа олохгүй, ямар ч арга байхгүй, арга тасрах, гайхшаа барах); **ая алдах** (сэтгэлд зохисгүйдэж зан ааш хувирах); **барьц алдах** (итгэж түших газаргүй болох, барил алдах ч гэнэ); **баримжаа алдах** (баримталбал зохих зүйлээс зөрчих хазайх); **гам алдах** (бнед тогтоосон дагавал зохих журмыг эс бнелүүлэх); **гол алдах** (үйл ажилд баримталбал зохих баримжаа чиглэлээ алдах); **дуулж алдах** (байдаг чадлаараа дуулах); **замбараа алдах** (эх зах, эмх цэцгүй болох); **ёс алдах** (хэв журмаас гаж буруугаар явах); **зүрх алдах** (айж эмээн үл зориглох); **инээд алдах** (гэнэт инээх); **мөр алдах** (мөшгөх замгүй болох); **нүд алдах** (олон буюу их юмны бараанд тодорхой олж харахгүй болох); **тоо алдах** (тоолж баршгүй); **өдөж алдах** (зориуд зүгээр суулгахгүй оролдох); **санаа алдах** (шүүрс алдах); **санамж алдах, сэрэмж алдах** (бодож болгоомжлохгүй осолдох); **шүүрс алдах** (зовиних, гэмших мэтэд амьсгалыг урт авах); **тав алдах, тух алдах** (тохигүй байх); **томоо алдах** (томоотой хүн томоогүй байдал гаргах); **тэмцэж алдах** (үйл ажилд хүчлэн мэрийж тэмцэх); **уйлаг алдах** (а. хайрлан харамсах; *өөрөө өгчөөд хойноос нь уйлаг алдах юу байх вэ;* б. царай алдах); **уулга алдах** (бэлэнчээр аашлах); **ухаан**

алдах (а. ухаан балардан муужрах; б. юмыг үзэх сонирхох зэргэгт машид баярлах); **амь алдах** (амь бусних); **үзэж алдах, үзэлцэж алдах** (а. үйл ажилд мэрийн чармайх; б. хүчлэн маргаж тэмцэлхийлэх); **хээгээ алдах** (ичих зовохоо болих); **царай алдах** (а. өнгө зүс гутаж муудах; б. хяраг аминч зан байдал гаргах); **цус алдах** (цус гэнэт их гоожих); **чанараа алдах** (ямар нэгэн шалтгаанаар юмны яс чанар урдахь байдлаасаа доройтох); **чиг алдах** (зүй зарчим, гол шугамаас гажиж хазайх); **эх захаа алдах** (дээр дор, ах захын ялгаа ёсыг үл хайхрах); **алийгаа алдах** (яах ч учраа олохгүй болох); **мөрий алдах** (бооцолж наадахад хожигдсон нь хожсондоо бооц өгөх); **сахилга алдах** (журамлан дагаж явбал зохих зүй зарчмаас зөрчиж буруудах); **тамир алдах, тэнхээ алдах** (хүчин чадал буурч доройтох); **нойр алдах** (унтаж үл чадах); **мэдээ алдах** (мэдрэл нь үгүй болох); **итгэл алдах** (найдсан хүсэл үл бүтэх, итгэмжгүй болох); **цаг алдах** (а. ажиллах цагийг гарздах; б. үйл ажлын зохистой үеийг үргүй өнгөрүүлэх); **хөл алдах** (а. усанд хөл газар хүрэхгүй болох; б. худалдаа наймаа хийхдээ хөрөнгөө хохирч сүйрэх; в. их буюу олон юмны дотор орж аль учраа олохгүй болох; г. жагсаж хөл нийлүүлэн явахад хөлөө сольж гишгэх); **үг алдах** (бусдад хожим гэмшилтэй өө сэвтэй үг санамсаргүй хэлчих); 14. үйлт нэрийн ирээдүй цагийн төлөвт үгтэй хоршиж захирах хүсэхийн төлөвөөр үл тоомсорлох санаа илэрхийлнэ; *ном үзэхээ алд; гүйхээ алд;* **алдаж онох** (сайн муу ээлжлэх).

АЛДАШ я р и а алдас; **алдаш алдас** (үйл явдалд алдал эндэл гаргахгүй газарт алдаа дутагдал гаргах).

АЛДЛАХ 1. юмыг хоёр гар сунгаж хэмжих; 2. хоёр гараа сунган дэлэх.

АЛДЛУУЛАХ алдлахын үйлдүүлэх хэв.

АЛДРАХ 1. уясан, торгосон юм сулран тайлагдах; *уяа нь алдарчээ;* 2. бусад үгтэй нийлж сулрах гэсэн утга гарна; **бие алдрах** (тэнхээ муу, бие сул байх); **зориг алдрах** (зориг сулрах); **ял алдрах** (ялаас хэлтрэн гарах).

АЛДРУУЛАХ алдрахын үйлдүүлэх хэв.

АЛДУУЛ алсан сарнисан юм. *алдуул мал.*

АЛДУУЛАХ 1. алдахын үйлдүүлэх хэв; 2. барьсан уясан зүйл алдрах унах; *морь алдуулав; уяагаа алдуулах;* ☆ **цус алдуулах** (цус ихэд гарч тогтохгүй болох); **барьц алдуулах** (а. барьсан барьцыг тавиулах; б .мэгдэн сандруулах).

АЛДУУРАХ алдрах үйл аяндаа болох; *уяа алдуурав.*

АЛДУУРЧИХ алдуурч орхих.

АЛДУУШ алдаш, алдас; *алдууш алдах.*

АЛДЧИХ алдаж орхих.

АЛДЧИХАХ алдчих.

АЛЖААЛ ядрал, зүдрэл.

АЛЖААЛГАХ алжаахын үйлдүүлэх хэв.

АЛЖААЛГҮЙ ядрашгүй зүдэшгүй, төвөг бэрхшээлгүй.

АЛЖААНГУУ баахан баахан алжаасан.

АЛЖААС 1. зүдэл, зүдэх; 2. эндүүрэл, алдаа.

АЛЖААХ х ү н д э т г э л хүний ядрах цуцах; *алжаах цуцахыг үл мэдэх.*

АЛЖУУРАЛТАЙ 1. хэрэг явдлын будлиан самуурал үлэмж; 2. үйлдэх явахад бэрхтэй, төвөгтэй.

АЛЖУУХ зовиурлах, залхуурах.

АЛЗАХГҮЙ 1. бардаагаар чадах; 2. юмнаа давагдахгүй, ажрахгүй; *хүйтэнд алзахгүй.*

АЛЗАШГҮЙ үл торох, алзахгүй ☆ **алзашгүй ертөнц** (хуучин бичиг сударт манай дэлхийг ийнхүү нэрлэсэн байдаг).

АЛЗУЛ: алзул цэцэг у р г а м а л сараанын нам, үзэсгэлэн цэцэгтэй, үндсэндээ төмстэй буй.

АЛИА 1. хошин зантай, хошинч; 2. бага хүүхдийн дүрсгүй шог зан.

АЛИАДАХ хэгэрхий алиа болох.

АЛИАЛАХ алиа зан гаргах.

АЛИАЛУУЛАХ алиалахын үйлдүүлэх хэв.

АЛИАРАХ алиа болох.

АЛИАРХАХ алиа байдал гаргах.

АЛИАРХУУ алиа хошин зантайвтар.

АЛИАТАХ алиа байдал гаргах.

АЛИАХАН баахан алиа.

АЛИВ өгөөч; *алив нааш нь; наад номоо алив; хоолноосоо алив.*

АЛИВАА 1. хамаг; 2. энэ тэр, ямарваа; *аливаа юм; аливаа хэрэг; аливаа ажил.*

АЛИГ гэдэн годон, шалиг зантай; **алиг шалиг** х о р ш..

АЛИГАЛИ: **алигалийн үсэг** Монголын Аюущ гүүш, самгарди хэлний аялгуунаас авч зохиосон арван зургаан эгшиг, гучин дөрвөн гийгүүлэгч үсэг.

АЛИЙВ аялга үг; *алийв хаа байна миний хүү!; алийв та минь бушуулаарай!; алийв өргөцгөөгөөрэй!; алийв ирцгээ нөхөд минь!; алийв босооч!; алийв хичээлээ давт!.*

АЛИМ у р г а м а л шар буюу улаавтархан өнгөтэй, хүчтэйвтэр амттайхан, бөөрөнхий жимс; **алимын мөхлөг** (алимын дотор байх, тарианы мөхлөг шиг болоод зажлахад шарчигнах үр); **алимны мод** (цагаан буюу улаан цэцэгтэй, алим ургадаг нэг зүйл мод).

АЛИМАД аливаа; *алимад явдал .*

АЛИМХАН жижиг алим.

АЛИН аль; *аль алин; аль алинаас ч илүү сайн юм; аль алинд нь бий.*

АЛИРВАС а м ь т а н муурын нам, жавхгар биетэй, уртавтар хөлтэй, байдал барс нохой хоёрын төлөвтэй, үс налархай, жижигхэн жижигхэн бараан толботой, шаравтар зүстэй амьтан.

АЛИРС у р г а м а л голцуу шугуйд ургах, намхан харгил бутны жимс, жимсний өнгө улаан, навч мөнх ногоон бөгөөд хальслаг зузаан, идэж болдог, эмэнд ордог.

АЛИС үрлэж боловсроогүй үед хонгорцогтой нь хадсан буурцагт тарианы өвс.

АЛИУС 1. үр тариаг хадахад газар унасан үрээс гарсан өвс; 2. үерт дайрагдаад дахин ургасан өвс.

АЛИШИМ мөхлөг буурцаг, өнгө харавтархан, амт халуун нэг зүйл үр; поваар ч гэдэг.

АЛМАГАЙ хянамж болгоомжгүй хүн.

АЛМАГАН идэх уух юмны амт үлбэгэр муу, идэхэд тааламжгүй.

АЛМАЙ хуудам, болгоомжгүй, мартамхай, өөр зүйлд саатаж чухам хэргийг орхимтгой; *алмай хүн.*

АЛМАЙДАХ хэтэрхий алмай байх.

АЛМАЙРАХ үйл явдлыг мартах, алгасах, үйл явдлыг анхааралгүй өнгөрүүлэх.

АЛМАЙРУУЛАХ алмайрахын үйлдүүлэх хэв.

АЛМАЙТАХ алмай байдал гаргах.

АЛМАЙТУУЛАХ алмайтахын үйлдүүлэх хэв.

АЛМАН дугаригийн хэлтгий хэлбэр; **алман саран** (шинийн наймнаас урагш, мөн хорин гуравнаас хойших үеийн хэлтгий тахир сар); **алман сүх** (хэлтгий саран хэлбэрт дугуй иртэй сүх).

АЛМАНЦАГ нохой баавгайн зулзага.

АЛМАРАД у р г а м а л нэг буюу олон наст ороонго ургамлын төрөл; шаравтар улаан өнгөтэй, идэхэд хүүрэг бөгөөд амттайхан, гонзгойвтор хэлбэртэй махлаг жимс.

АЛМАРАХ дадсан сурсан зүйлийг орхих буюу явдал цалгай задгай болох.

АЛМАС I 1. хүн дүрст нэг зүйл амьтан; 2. ардын домогт эм шулам.

АЛМАС II өнгөгүй тунгалаг чанар хатуу нэг зүйл эрдэнийн чулуу.

АЛМАТ усны хавчиг.

АЛМУУН амт муутай.

АЛМУУР 1. суга таяг; 2. суман онгоцонд суугчдын тулах хоёр мод.

АЛРИХ өвс ногоо гишгэгдэх, эсвэл салхины аясыг даган налж унах, налрах ч гэнэ.

АЛРИХАЙ гишгэгдэн налж унасан нь; *өвс ногооны алрихай.*

АЛС 1. бөглүү, хол; **алс хол** х о р ш. *алс хол хязгаарт суух; алсаас харах; алсыг ширтэх; алсын замд аялан явлаа;* 2. хожим; **алс нь** (хожим, хэт нь); **алсдаа** (хожим); **алсын бодлого** (холын бодлого); **алс алавхийх** (морин дээгүүр алсаас харайн өнгөрөх).

АЛСАХ: **уул алсах** амьтан ба үүл будан зэргийн уулны дээгүүр нэвтрэн өнгөрөх.

АЛСДАХ хэтэрхий хол байх.

АЛСЛАХ хоорондоо салж хол болох.

АЛСУУН: алсуун гас а м ь т а н толгойдоо шар чандартай, хар цагаан алаг шувуу, махы нь идэж болно.

АЛСХИ холын; **алсхи зам** (алс холын аяны их зам).

АЛСХИЙХ санаа сэтгэл амсхийх, бие түр зуур амрах.

АЛТ (Н) 1. хувилахуй ухааны нэгэн язгуур махбод; шар өнгөтэй төмөрлөг эрдэнийн зүйл; давтагдан сунах чанар үлэмж; 2. з ү й р л э с э н маш чухаг, ашид хувиршгүй; *алтан амь; алтан дэлхий;* 3. бусад үгтэй хамтран; алтан хушуу (хов, *алтан хушуу өргөх);* алтан **хушуудах** (хов зөөх, ховлох); **алт шарах** (мөнгө зэс зэргийг алтдах, алтаар бүрхэх); *алтны дэргэдэх гууль шарлана* з ү й р; **алтны орд; алтны уурхай; алтны газар** (алт малтаж олох газар); *алты нь аваад авдры нь*

хаях (оньсого); **чих нь алт болог** (битгий сонсоосой гэсэн утга); **алтан өлгий** (а. алтаар цутгасан ембүү; б. утга зохиолд, төрсөн эх нутгаа энхрийлэн магтах нэр); **алтан өнгө** (алт мэт шар өнгө); **алтан тахиа** (а. хятадын тэжээвэр тахиа; б. монгол бичиг сударт нарны ёгт нэр); **алтан ураг** (Чингэс хааны угсаа төрлийнхөн); **алтан хонхорь** (эртний цагт малгайд унжуулах уртхан бяцхан хонх, хангир жингэр дуугардаг); **алтан хөөрөг** (цохивор хөгжмийн зэвсэг, төмөр гуулиар бяцхан бортого мэт үйлддэг, доод амсар тэгш, өндрөөр долоон ямх гаруй, өргөөшөө тэнхлэгээрээ таван ямх шахам, жаазан өлгүүрт дүүжилж модон цохиураар цохиж хөгжимддөг); **тэргүүлсэн алтан хөөрөг** (нэг өлгүүрт нэг хөөрөг дүүжилж, хөг эгшиг харилцан өөр өөр бүгд арван хоёр хөөрөг зэрэгцүүлэн тавьж цохьдог хөгжим); **жигдэрсэн алтан хөөрөг** (нэг өлгүүрт хэмжээ ижил, нимгэн зузаан ялгаатай арван зургаан хөөрөг дүүжилж цохих хөгжмийн зэвсэг); **алтан хуудас** (шарах, ширдэхэд хэрэглэхээр нухмаллаж маш нимгэн болгон дэвтэрлэсэн алт); **алтан хорголж** (алтыг нухмаллаж үрэл мэт бөөрөнхийлсөн алт); **алтан цаас** (өнгө алт мэт болгосон цаас); **алтан чулуу** (алтан өнгө холилдсон нэгэн зүйл чулуу, эмд ордог); **алтан элс** (тусгай байдал бүхий элсний нэр, дүр төлөв хэдэн зүйл бий); **алтан утас** (а. алтыг шувтран татаж утас мэт нарийн болгосон буюу эсвэл нимгэн алт, алтадсан нимгэн зэс мэтийг утсанд ороосны нэр; б. у р г а м а л уул хөдөөд ургадаг алтан утас шиг шилбэтэй шар цэцэгтэй нэгэн зүйл ургамал); **алтан цэцэг** у р г а м а л (төрөл хэдэн зүйл бий, эмд ордог); **алтан цэгцүүхэй** у р г а м а л (тоорын цэцэг мэт болоод уртхан хэлтэстэй, тоорцогноос нь шар түрүү гарч цэцгийг бүрхэн хучдаг, нэг зүйл цэцэг); **алтан цацаг** у р г а м а л (халуун орны нэгэн зүйл ургамлын нэр, эмэнд ордог); **алтан хумхи цэцэг** у р г а м а л (ороомог цэцгийн адил, хэлтэс дан, өнгө улбалзан нүд эрээлжлүүлнэ); **алтан хундага цэцэг** у р г а м а л (нэгэн наст ургамал, навч, ишинд тэврэн ургадаг, цэцэг улбар шар өнгөтэй, хүйс бяцхан, цэцэглэхдээ дүгрэгхэн хундаганы адил, үр муруй барчгар); **алтан товч** у р г а м а л (хээр хөдөөд ургах нэг зүйл өвс); **алтан харгана** у р г а м а л (харганын зүйл, хөвд хөдөөлөг, их төлөв уулын хяр, ар, шил газар ургадаг; өндөр нь нэг метр хүрдэг, салаа цөөн, алтан өнгийн хальстай, цайвар ногоон навчтай, шар цэцэгтэй); **алтан сиймхийлэг цэцэг** у р г а м а л (улбар шар өнгөтэй, гялтганам сайхан цэцэг); **алтан ороонго цэцэг** у р г а м а л (модонд ороон ургадаг, өндрөөшөө хэд хэдэн хос алд, зэллэн нэг салаанд хэд хэдэн навч гарч, салаа тутам арван хэдэн цэцэг цэцэглэдэг, таван хэлтэстэй, томоохон хүйстэй, улбар шар өнгөтэй); **алтан бадам** у р г а м а л (өнгө шар, бад хэлбэртэй нэгэн зүйл цэцэг); **алтан бидэр цэцэг** у р г а м а л (хэлтэс нь давхцаж бидэр мэт харагдах бяцхан цэцэг, гялбалзсан сайхан улаан өнгөтэй); **алтан бялзуухай цэцэг** у р г а м а л (иш нь элсэн өнгөтэй, үслэг навч хажуу хоёр этгээддээ хоёр салаа ургасан нь бялзуухайн жигүүр мэт; бут бутаар урган, залгаж цэцэглэх цэцэг); **алтан гагнуур** у р г а м а л (хангайн уулархаг газар ургадаг, цэцэг улаан, үндэсний хальс чилгэр, нутгийн ард, үндсийг малын шарх бэртэнгэд хэрэглэнэ; булагны эм ч гэж нэрлэдэг); **алтан дусал цэцэг** у р г а м а л (хоёр гурван давхар хэлтэстэй, улбар шар цэцэг; навч цэцгэнд нь тунасан шүүдэр шороонд дусвал даруй үндэс ургана); **алтан зул цэцэг** у р г а м а л (хар сэвхтэй, цагаан, улаан, шар гурван зүйлийн өнгөтэй, хэд хэдэн хүйс нэгэн дор багтаж сүлжсэн зулын адил цэцэг; сэрүүн цэцгийн навчаас баахан явцуу навчистай); **алтан зүрж** у р г а м а л (дорнод Гималайн уулаас гаралтай мөнх ногоон модны жимс; хэлбэр төрх амтат зүржтэй төстэй, хэмжээгээр арай багахан, улбар шар арьстай, амт исгэлэн, анхилуун цагаан цэцэгтэй, урт өргөслөг навчистай); **алтан божирго** а м ь т а н (алтан шар, ногоон, үнсэн хөх хольцолдмол өнгөтэй бялзуухай, яруу дуутай, гэрт тэжээдэг); **алтан цуравдай** а м ь т а н (хушуу улаавтархан, өнгө цайвар шар, бидэргүй бялзуухай); **алтан хацар** а м ь т а н (хушуу шовхгор, толгой бие моголцог бөөрөнхий, хайрс нарийн, хагадас үлэмж, хүч ихтэй загас, зарим нь алд илүү урт); **алтан хараацай** а м ь т а н (уран хараацайгаас том, хушуу ахар, бие цох хар, омруу цагаан, цагаавтархан бидэртэй, жигүүр уртавтар шовх нарийн, нисэх нь хурдан); **алтан зулай** а м ь т а н (толгойдоо шар чандартай нэгэн зүйл хун шувуу); **алтан жигүүр** а м ь т а н (янз төрх шар алаг дунгартай адилхан, ар улаан, жигүүр хар, дундаа нэгэн хэсэг шар чандартай, алт мэт гялбалзах бялзуухай); **алтан загас** а м ь т а н (гурван салаа сүүлтэй, их бага адилгүй, зүйл бүрийн өнгө бий; гэрт тэжээн чимэглэл үзэсгэлэн болгодог); **алтан гургалдай** а м ь т а н (зонхилох өнгө шар, жигүүрийн өд бараан, нэгэн зүйл дуучин шувуу, эрэгчин эмэгчнээр хамт нисдэг, хоёрдугаар сараас намрыг дуустал жиргэдэг, эрэгчний дуу яруу сонсголтой); **алтан нүдэн бялзуухай** а м ь т а н (нүд шар, цэцгий хар, сүүл охор, бие цох хар бор, хүзүү алаг, богшроготой адилхан бялзуухай; эрхийгүй учир

модонд сууж чадахгүй); **алтан нүдэт улар** амьтан (нэгэн зүйл гургуул; хуй гургуултай адил болоод өрөвлөгт нь тогосных шиг ногоон нүд бий): **алтат мич** амьтан (сүүл урт, үс шар, алтан утас мэт гялалзсан үстэйн нэгэн зүйл мич); **алтан гадас** зурхай (алтан мөнгөн шаргын ордын сүүл талын том од; тэнгэрийн архилгад оршиж, дэлхийн бөмбөрцгийн хойт зүгийг заана); **алтан соёмбо** (Б Н М А Улсын баатар цол шагнагдагсдад олгох медаль); **алтан гадас одон** (улс нийгмийн үйлст гарамгай гавьяа байгуулагсдыг хөхүүлэн шагнах Б Н М А Улсын нэгэн зүйл одон тэмдэг); **алтан мөнгөн шарга** зурхай (умард туйлын орой тушаа, Тэнгэрийн гох, Тэнгэрийн багана, Тэнгэрийн идээний гэр орддын хооронд орших долоон одны орд; энэ ордын нэгдүгээр одыг Алтан гадас гэдэг); **алтан мэлхий** зурхай (тэнгэрийн өмнөдөд Хувилгааны ордоос өмнө тийш, Дагалзах дарга, Хувилгааны орд, Тэнгэрийн түлхүүр, Цэрэг тэргүүлэгч, Лаг мэлхий, Энхжингийн шувуу, Өмнөд цэрэг, Тэргүүлэгч орддын хооронд орших таван одны орд).

АЛТАНХУА: алтанхуа цэцэг ургамал усанд ургах цэцэг, байдал лянхуатай адил бөгөөд бяцхан; тоорцгоос дараалан цөм улбар шар өнгөтэй, долоон хэлтэстэй, нэгэн ишинд хэд хэдэн цэцэг цэцэглэдэг.

АЛТАДМАЛ алт шарсан, түрхсэн эд юм.

АЛТАРГАНА ургамал ой, бутархаг газар ургадаг олон наст ургамлын төрлийн нэг зүйл.

АЛТАЧ алтаар юм хийдэг хүн.

АЛТГАНА I алтан харгана.

АЛТГАНА II амьтан бие цох шар өнгөтэй нэг зүйл хараацай.

АЛТДАХ алтаар будах, алт түрхэх; *зургийн гуу алтдах.*

АЛТДУУЛАХ алтдахын үйлдүүлэх хэв.

АЛТЛАГ 1. алттай, *алтлаг эд;* 2. алт мэт; *алтлаг өнгө.*

АЛТЛАХ алттай болгох.

АЛТСАН: алтсан цэцэг ургамал өнгө шар, хэлтэс уртлаг, салхинд үлээгдэн хөдлөх нь эрвээхэй дэвэхийн адил сайхан.

АЛТШИН: алтшин цэцэг ургамал байдал дүрэм эрвээхэйн адил, салхинд гулзалзах нь дэвэлхийлэх мэт, цэцгий нь түүж няцачвал **алт шиг.**

АЛУУЛАХ 1. алахын үйлдүүлэх хэв; 2. алагдах.

АЛУУН 1. эх зах, ичгүүр сонжууруа алдсан; *ичгүүргүй алуун амьтан; алуун зан;* 2. бодол муутай; болхи бойдуу.

АЛУУРАХ алуун зан гаргах; ***чи дэмий алуурах хэрэггүй.***

АЛХ (АН) I 1. төмөр мод зэрэгт нүх гарган иш хийж гараар барьж дэлдэх хадахад хэрэглэх багаж; *алх хадуур; төмөрчний алх;* 2. механизмд байдаг зүйл бүрийн цохидог хэрэгсэл.

АЛХ II: **алхан хээ** хоёр алх зөрүүлэн тавьсан мэт нэг зүйл хээ; *дан алх; давхар алх.*

АЛХ III нөмрөг дах зэргийн заамын дор, уртад хийсэн үс.

АЛХ IV дундад чихэн дахь сонорын эрхтний өчүүхэн ясуудын нэг; ☆ **алх жэмсэг** (хазаар хударганы төмөр).

АЛХАА 1. явахад хөлийн хөдлөл, алхаш; алхам; *алхаагаа хурдасгав; алхаа гишгээ;* 2. морины явдал; *алхаатай морь; гүйн хар алхаатай; замын хар алхаатай.*

АЛХАГ 1. залхуу хойрго, заваан задгай; 2. арвич, хэтэрхий мэдэмхий.

АЛХАЙХ назгайран байх, залхуурах; *ажилгүй алхайх муу.*

АЛХАЛХИЙЛЭХ 1. давтан давтан алхах; 2. нялх хүүхдийн хөлд орж эхлэх.

АЛХАМ 1. явахад өрөөсөн хөл урагш нэг гишгэх хэм; 2. нэг алхах хэмжээ; *нэг алхам урагшаа, хоёр алхам хойш* (В. И. Ленины зохиол); 3. зүйрлэсэн давшилт, үүсгэл; *тустай алхам хийх; үйлдвэрийн талаар алхам урагшлав.*

АЛХАМЛАХ алхмаар хэмжих; *тариалах талбайгаа алхамлан хэмжиж байв.*

АЛХАСХИЙХ түргэн алхах.

АЛХАХ 1. нэг нэгэн алхмаар давшилхийлан явах; *алхаад яв!; дээгүүр нь алхаж гарав;* 2. алгасах, давж өнгөрөх; *бартаа саадыг алхаж давах.*

АЛХДАЛ алхаа; *алхдал их, алхдал бага.*

АЛХИЛДААН хүч тэнцүү буюу харилцан буурай зодолдоон.

АЛХИЛДАХ алхихын хамтран үйлдэлдэх хэв; алхилдаан болох.

АЛХИУЛАХ 1. алхихын үйлдүүлэх хэв; 2. алхигдах.

АЛХИХ занчих, зодох.

АЛХЛАСХИЙХ түргэн түргэн алхлах.

АЛХЛАХ яарч шамдан алхаж зорчих.

АЛХЛУУЛАХ алхлахын үйлдүүлэх хэв.

АЛХУУЛАХ 1. алхахын үйлдүүлэх хэв; 2. алхагдах.

АЛЦ шагайны хажуугийн хотгор этгээдийн нэр, тэмээ ч гэнэ.

АЛЦАА салтаа.

АЛЦАГА: алцага алцага хийх алцан алцагар юмны үргэлжлэн хөдлөх.

АЛЦАЙЛГАХ 1. алцайхын үйлдүүлэх хэв; 2. алцайх.

АЛЦАЙХ алцагар болох, хөлийг (адгуус малын хойт хөлийг) хоёр тийш болгох; *алцайхад булцайх* о н ь с о г о.

АЛЦАЛЗАХ алцас алцас хийх, хөлийг (адгуус мал хойт хоёр хөлийг) хоёр тийш тэлж явах хөдлөх.

АЛЦАН хүн амьтны хөл, төрөлхөөс хоорондоо хол зайтай төрсөн.

АЛЦАНХАЙ алц.

АЛЦАС: алцас алцас хийх алцан алцагар юмны байн байн хөдлөх.

АЛЦАСХИЙХ өчүүхэн зуур алцайх.

АЛЦГАНАХ 1. алцага алцагэ хийх; 2. эмэгтэй хүний савсаг байдал гаргах.

АЛЦГАР 1. хөл хажуу тийш хэтэрхий холдсон; 2. навтгар, хөл богино, тагдгар; *алцагар намхан ширээ.*

АЛЦГАРДАХ дэндүү алцгар байх.

АЛЦТАЙ сновчтой; *та ганцхан алцтай уг хэлэв.*

АЛЧИМ алхам, алчим алхам х о р ш..

АЛЧУУР юм арчих хэрэгсэл; *нүүр гарын алчуур; нусны алчуур; тогооны алчуур;* ☆ **саадаг алчуур** (аяны хүний аяга агуулах бүснээсээ зүүдэг хуппастай уут); **аяганы алчуур** (дээр үед доод тушаалын албаны хүний бүснээсээ зүүж, аяга агуулдаг хормойдоо хүрэхүйц урт уут); **толгойн алчуур** (толгой бооход зориулсан эдлэл).

АЛШ нядлах мал; **алш хийх** (идшинд мал алах).

АЛЬ I 1. асуух, лавлах, ялгах, заах утгаар; *аль вэ?; аль вэ? хаа байна?; аль зүгээс ирэв?; аль алинаас нь асуу; аль алинд нь өг!; аль сайны нь ав л даа; аль хүртэл унших вэ?; аль ч газар адилхан; аль морий нь унах вэ?; аль хир хүн бэ?; аль зэрэг байна?; аль аль нь зүгээр;* **аль ааш нь дайрах бол?** (ямар ааш нь тохиолдох бол); 2. хамаг, бүх, хир чинээгээр, бишгүй, олон; **аль муугаа үзэх** (хамаг зовлонгоо эдлэх); **аль муугий нь дуудах** (бүх муугий нь дуудах); **аль муугий нь хүлээх** (муу бүхнийг хүлээх); **аль байдгий нь илчлэх** (хамаг байдгий нь илрүүлэх); **аль сайны нь сонгох** (хамгийн сайны нь шилэх); **аль болох аргаар** (ямар нэг аргаар); **аль чадах чинээгээр** (хир чадлаараа); **алиныг нь тэр гэх вэ** (бишгүй байдаг юм); 3. цаг заасан утгаар; *аль эртнээс хийх; аль намайг хотод байхаас аваад; аль хэдий нь; аль зунаас эхлэн одоо хүртэл;* **аль дивангарын** (маш эртний); 4. эсвэл, үгүй бол гэсэн утгаар; *чи хэлнэ үү, аль би хэлэх үү?; би явах уу, аль та явах уу?.*

АЛЬ II 1. өг гэсэн утгаар; *номоо аль!; морио аль!; үзгээ аль!;* 2. туслах үйл үгийн чанараар өг гэсэн санаа илэрхийлнэ; *чи аваад аль!; энэ номыг уншаад аль!; миний морийг ацраад аль!; надад босоод аль!; чи санаагаа хэлээд аль.*

АЛЬБОМ дуу, шүлэг, зураг, марк зэрэг эүйлийг цуглуулахад зориулсан тусгай дэвтэр; *гэрэл зургийн альбом, маркийн альбом.*

АЛЬХАН хаахна, ямархан; *тэр уулын альхан талд нь байна вэ?.*

АМ (АН) I 1. хүн амьтны уруулын завсрахи сүв; *том ам; муруй ам;* 2. хүн амьтны хушуу уруулын завсрахи, багалзуур хүртлэх хөндий; *ангайх амтай, залгих хоолойгүй* о н ь с о г о; *алтан дөрвөн туурай нь гялалзаж, аман дотроо цагаан соёо цухалзуулан ...* (хурдан морины цолоос); *шувууны ам; амаа зайлах; аман дотор; аман дотроо үглэв; амандаа орсон өөхийг хэлээрээ түлхэн гаргах* з ү й р; **ам гэмтэх, ам домтох** (хүүхдийн аман дотор яр гардаг өвчин тохиох); **ам хатах** (ам хуурай болох); **ам цангах** (унд хүсэх); *чонын амнаас гарч барсын аманд орох* з ү й р: **ам заваарах** (шүлс налдааран аман дотор аягүй болох); **ам жишлэх** (цангасан амьтны өчүүхэн юм уухыг); **ам захиа** (амаар уламжлан хэлүүлсэн үг); **ам зөөлөн** (а. морь малын, ам татах залахад ялгуум эелдэг; б. хүний үг ялгуум аятай); **амаа мэдэхгүй** (морь малын хазаарт дасаагүй); **ам зөрөх** (хоёр хүний хэлсэн үг хоорондоо үл тохирох); **ам зөвшөөх** (бичгээр биш амаар ярилцан тохирох); **ам задгай** (үзсэн, сонссон бүхнээ хамаагүй илрүүлэн ярьдаг); **ам дордойх** (садан төр-

лийн хүмүүсийн хоорондоо бага зэрэг хэрэлдэж муудалцах; *ам дордойвч элэг дордойхгүй хууч.*); **ам дагах** (бусдын үгийг зөвшөөрөн хүлээх); **ам дагалах** (бусдын хэлэлцэхэд хөндлөнгөөс зоримгоор оролцон ярилцах); **ам озох** (амаараа сорон шавхийтэл үнсэх); **ам сул** (а. морь малын ам *зөөлөн*; б. хүний ам задгай чалчаа); **ам хагалах** (а. эмнэг адуу малыг анх эдлэгээнд сургаж дасгах; б. ам нээх); **ам хатуу** (а. морь малын хазаартаа ам нь дийлдэхгүй тэмүүлдэг нь; б. хүний үг ухачламтгай ширүүн); **ам халах** (а. морь малын ам, амгайдаа холгогдон улайх; б. хүний сэтгэл нь хөөрч яриа нь нэмэгдэх; в. баахан халамцаж үг олшрох); **ам хүрэх** (амсах); **ам чагтуун** (морины ам дэндүү хатуу); **ам зүгшрэх** (а. морь малыг унаж сургахад ялгуум эелдэг болж эхлэх; б. хэлэх өгүүлэх үг, унших дуудах бичигт хэл дадаж дасах); **ам ихтэй** (хир хэмжээнээс хэтэрхий давамгай бардам үгтэй); **ам муудах** (олны ам ихэвчлэн муулах тийш хандах); **ам муруйх** (харилцан муудаж хэрэлдэх); **ам нийлэх** (хүмүүсийн үг өгүүлэл хоорондоо ягштал тохирох); **ам сайжрах** (юманд олны ам ихэвчлэн магтах тийш хандах); **ам сулрах** (юманд олны ам баахан муудах); **ам нээх** (а. зөвлөлдөх ярилцахад анх эхлэн хэлэлцэх; б. бэрхшээж байсан зүйлийг сая гарган хэлэх); **ам таглах** (а. хариулж болшгүй үгээр хариу тавин дуугүй болгох; б. ор нэрийн төдий зүйлээр аргацаан бөглөж өнгөрүүлэх); **ам удаан** (дугуй авад үг гаргаж хэлэхгүй); **ам түргэн** (зан түргэн, юуны урьд үг хэлэлцэх дуртай); **ам хавчих** (өгүүлэх хэлэлцэхэд сэргэмжлэн үг дуугүй суух); **ам хаацайлах** (ам хаах); **ам хаах** (ам таглах); **ам улжих** (аж төрж чадахгүй, юм элбэг газар очиж амь зуух); **аман зууш болох** (хүний ичгүүрт муу явдал энд тэндгүй тархаж жигшин хэлэлцэх); **амаа татах** (хэлэхгүй, ярихгүй дугуйхан байх); **амаа өгөх** (бусдад заавал тэгнэ гэж батлах); **ам шүд алдах** (ам алдах); **ам хүлээх** (а. амаар зөвшөөрөх; б. хэлэлцэх зөвшилдөх зэрэгт бусдын ам харах); **ам хуурай суухгүй** (а. уван цуван үргэлжлэн идэх; б. дугай байдаггүй); **ам хурдан** (санасан бодсоноо бусдаас урьдчилан хэлэх зантай); **ам харах** (хүний юу хэлэхийг хүлээх); **ам хамхихгүй** (хүн амьтны үргэлжид дуугарч байх); **ам хамхих** (өгүүлэх хэлэлцэх газарт цэнэж үг дуугүй суух); **ам хазайх** (олны ам баахан муудах); **ам хагарах** (а. бэрхшээж байсан зүйлийг сая хэлэх; б. олны дотор зовохгүй ярих); **аман дээрээ сүрхий, ачир дээр базаахгүй** (хэлэх хийх хоёр нь адилгүй); **ам ажил хоёр нь зөрөх** (их ярьж бага хийх); **ам шаах (бурангуйлан тулгах); ам гарах** (бардамнан ярих); **ам гарздах, ам бузарлах** (бусдад найдаж хэлсэн зүйл бүтэхгүй болох); **амны гамхи** (амаар татах тамхи); **амны ус** (уух ус); **амны зууш болох** (бусдад шоовдорлогдон яригдах); **амны гарз** (хэлээд хэлээд биелэхгүй); **амны гийгүүлэгч** (үл хамарших гийгүүлэгч); **амны заваа гаргах** (бага сага юм уух); **амны цээр гарах** (а. амсахыг цээрлэсэн юмыг амсах; б. гэмшилтэй үг хэлснийхээ учрыг тайлбарлан ярих); **ам хагалах** (а. хүний бэрхшээн зовнисон хэрэг явдлыг үүсгэн хэлж өгөх; б. эмнэг адуу малыг анх эдлэгээнд сургаж дасгах); **амаа жимийх** (а. амаа хавчих; б. үг дуугарахгүй суух); **амаа барих** (а. өнгөрсөн хойно нь гэмших; б. амаа хавчих); **ам алдах** (тангараглах; *ам алдвал барьж болдоггүй, агт алдвал барьж болдог зүйр*); **ам асуух** (тавлаж асуух); 3. шилжсэн амсар нүх; *уутны ам; бууны ам; тогооны ам;* **аяганы ам зуух** (дөнгөж унд амсах); **нүхний ам** (нүхний амсар); **ам хамар** хорш.; 4. шилжсэн өндөр газрын хооронд голын дагуу байх газар; хоёр уулын хооронд байх нам газар; *Тарнийн ам; Түнхэлийн ам;* 5. шилжсэн үг, хэл; *хэл ам хийх; ам хэл татлах; хэл ам гаргах; амтай хэлтэй хүн; үг хэл гаргах; хэл амаа билүүдэх; үг хэлээ бараад байна билээ; ам хэлээр дороомжлох;* 6. шилжсэн өрхийн доторхи хүний тоо; *ам бүл олуулан;* **ам данс нэг** (нэг өрхөд тооцогдох); *ам хэд вэ?;* **өрх ам** хорш.; **хүн амын тоо бүртгэл** (бүх улсын хүний тоо бүртгэл); ☆ **аман хуур** (хөгжмийн зэвсэг, амаар үлээх буюу аманд тулган барьж хуурдана, төмөр хулс мэтийн зүйлээр үйлдэнэ); **аман зохиол** (зохиосон тодорхой эзэнгүй, амаар үүсч уламжлагдан хэлэлцэх зохиол); **аман хүзүү** (хүзүүний нэгдүгээр үе, толгойн яс, хатан хүзүү хоёрын хоорондох хүзүү); **аман хүзүү зангидах** (зангилааны нэр, тойрон гурваар гөрсний адил сүлжээлэн уях); **ам зом** (үйл ажилд завдамгай хөдөлгөөнтэй хүн; *тэр чинь ажилд ам зом хүн шүү);* **ам мөлт ,ам мөлтөс** (дөнгөж, урьдхан, ялимгүй жаахан); *дөнгөж цагт нь арай хожимдолгүй ам мөлтөс уулзав; ам мөлтөс ирэв; ам мөлтөс дуусчихлаа;* **ханын ам** (монгол гэрийн ханын нийлүүлэн боох уулзвар); **нохойн амаар нийлэх** (ханын амыг хоёр хоёр буюу гурван үдээртэй уулзраар буруу нийлүүлэх).

АМ (АН) II: **бөхийн ам** үгтуул бөхтэй барилдах эсэргүүцэл бөх; **аманд гарах** (үгтуул бөхтэй барилдахаар гарах); **ам үгтуул** (амлагдсан, амласан хоёр бөх); **ам үгтуул авах** (бөхийн засуулчдаас барилдах хоёр бөхийн цол чимэг зэргийг **өндөр дуугаар харилцан дуудалцах).**

АМ III эд барааны энгийн хэмжээгээр дөрвөлжилсөн хэмжээ; *ам торго; ам цаас;* **ам дөрвөлжин** (дөв дөрвөлжин).

АМАА ураг төрлийн ах хүмүүсийг хүндэтгэж нэрлэх нь.

АМАЛ амраа.

АМАЛДАХ ам алдах.

АМАНЦАР 1. юуны урьд ярих хэлэлцэх дуртай; *аманцар эхнэр;* 2. довтолъё гэж байн байн тэмүүлэх; *аманцар хээр.*

АМАР I 1. төвөггүй, хялбар, дөхөм; *амар дөхөмтэй зүйл; шат тавивал гарахад амар;* 2. зовнилгүй, тайван, энх түвшин; **амар жимэр, айван тайван** х о р ш.; **амар тавиу** (орон даяар энх түвшин); *биеийн амрыг харах;* **мэнд амар суух** (сайн суух); 3. мэндлэхэд хэрэглэнэ; *амар байна уу?* (дүү хүн ахмад настантай уулзаж мэндчилэхэд хэрэглэнэ); **та амар байна уу?; амар сайн уу?** (шинэ жилийн мэнд мэдэлцэж золгоход хэрэглэх үг).

АМАР II а м ь т а н байдал мөргөтэй адил, өнгө харавтар, нэг зүйл загас.

АМАРГАЛ аман хүзүү.

АМАРГҮЙ 1. тайван түвшингүй; 2. хэцүү, бэрх, төвөгтэй.

АМАРЖИХ 1. нийтээр амар тавиу болох; 2. бие жирэмсэн эхнэрийн хүүхэд төрүүлэх.

АМАРЖУУЛАХ амаржихын үйлдүүлэх хэв.

АМАРЛИГ а м ь т а н нуруу урт болоод маш бөлхөн нэг зүйл гөрөөс.

АМАРЛИНГҮЙ 1. зан ааль номхон эелдэг, тайван амар;2. ш и л ж с э н залхуу хойрго, лаглайн суудаг; *улс ардын чухал яаралтай үйл хэрэгт амарлингүй ханджээ.*

АМАРЛИХ 1. нийтээр амар тайван болох; 2. өвчин арилж эрүүлжих, харшлах зүйл устах; *өвчин тахал устаж амарлив.*

АМАРМАГ хүсэл дурлал, харилцан хайртай болсон.

АМАРМАГЛАХ амраг юугаа тэсгэлгүй эрэн хүсэх.

АМАРХАГ аманцар.

АМАРХАН 1. хялбар, хэцүү биш; *амархан зүйл; тэнд хүрэхэд амархан;* 2. мэндлэхэд хэрэглэх үг; *амархан сайн байна уу?* (ахмад хүнтэй мэндлэхэд); **амархан уу?** (нас ойр, ye зэргэлдээ хүмүүс харилцан мэндлэлцэхэд хэрэглэнэ).

АМАХ амрах, амсхийх

АМБАА ураг төрлийн зэрэг ах насны хүнийг хүндэтгэн жинхэнэ нэрийг цээрлэж ийнхүү дуудна.

АМБААР юм агуулахад зориулан бэлтгэсэн орон сав; *үр тариаиы амбаар.*

АМБАН I манжаас монголд суулгаж байсан төлөөний сайд; *Улиастай амбан; хүрээний амбан.*

АМБАН II их том; **амбан шар** (том шар).

АМБАС амбаны олон тоо; *амбасын яам.*

АМБУЛАТОРИ очсон өвчтөний өвчнийг үзэж үйлчлэх газар; *төв амбулатори; хүүхдийн амбулатори.*

АМГАЙ I морь малын аманд үмхүүлэх хазаарын нарийн гонзгор төмөр; *амгай зуулгах.*

АМГАЙ II буга агнахад дуугаргаж уриалах урам; ☆ **амгай яр** (хүний завжинд гардаг нэгэн зүйл яр).

АМГАЙВЧ амгай; **амгайвчтай морь** (амгай нь амнаас нь гараад эрүүн дор нь байгаа).

АМГАЙВЧЛАХ морь малын амнаас хазаарын амгайг огцруулан эрүүн доогуур болгох; *морио амгайвчлан услав.*

АМГАЙЧ амгай.

АМГАЙЧЛАХ амгайвчлах.

АМГАЛАН 1. бие сэтгэл зовлон зүдүүргүй энх эсэн; 2. мэндлэхэд хэрэглэх хүндэтгэл үг; *амгалан байна уу?;* 3. тайван, номхон, уурладаггүй; *амгалан тайван байдлыг алдагдуулах; амгалан хүн.*

АМГАЛАНДАХ хэтэрхий амгалан байх.

АМГАЛАНДУУ уужим тайван байдалтай; *амгаландуу хүн дээ.*

АМГҮЙ үг цөөнтэй, барагтай бол дуугардаггүй; *амгүйтэй адил хүн шүү дээ.*

АМДАХ 1. сая төрсөн нялх амьтны эхийнхээ хөхийг анх хөхөж эхлэх, *хурга амдах;* 2. цоровдох; 3. төмөр модны зэргээр юм хийхэд ац салаа гаргах; 4. ш и л ж с э н ирэх одох юмны урдаас тосон очих; *амдаж байж уулзав; зурмыг нүхний нь аман дээр амдаж байж барин авав.*

АМДУУ хуумгай мөчид.

АМДУУЛАХ 1 .амдахын үйлдүүлэх хэв; 2. амдагдах.

АМЁБА энгийн нүдээ үл үзэгдэх зөвхөн

микроскопоор харахад үзэгдэх нэг эст амьтан.

АМЖИЛ завдал; *амжил болсонгүй.*

АМЖИЛТ ямар нэг зүйлийг бүтээх, гүйцэтгэхэд олж чадсан ололт бүтээл; *амжилт гаргах; үйлдвэрийн амжилт; амжилт олох; амжилт хүсэх.*

АМЖИЛТГҮЙ ололт бүтээл муутай.

АМЖИЛТТАЙ үр бүтээл сайтай.

АМЖИХ завдах, чадах, цагт нь хийх.

АМЖУУЛАХ 1. амжихын үйлдүүлэх хэв; 2. бүтээх, гүйцэтгэх; *чиний захисныг би амжуулж үзье.*

АМИА: чимээ; чимээ амиа х о р ш.; *чимээ амиа гарахгүй байна.*

АМИАДАХ нааш хандах, эдэж зөөлрөх, юм бүтэх тийш болох.

АМИАРАА хувиараа, жичдээ, тусдаа; *амиараа явсан дээр; амиараа ярилцах; амиараа хичээл давтах.*

АМИАТАХ чимээ амиа гарах, цууриа гарах.

АМИЛАХ амь орох, сэргэж ухаан орох, сэхэх.

АМИЛУУЛАХ 1. амилахын үйлдүүлэх хэв; амь оруулах, сэхээх; 2. амилагдах.

АМИНДАЙ төрөл биш адил овогтой хүмүүс бие биесийг ийнхүү дуудна.

АМИНЧ зөвхөн амин хувиа боддог; дотночлон нууц харилцагч; өөрийгөө эрхэмлэн, өөрийн хэргийг бусад олон нийтийн хэргээс илүү чухалд үздэг; *аминч үзэл; аминч зан; аминч хүн.*

АМИНЧЛАХ хоорондоо дотночлох, нууцлан харилцах.

АМИНЧЛУУЛАХ 1. аминчлахын үйлдүүлэх хэв; 2. аминчлагдах.

АМЛАГ уран сэцэн үгтэй, хэлэмгий, аманцар.

АМЛАХ I 1. цохлон зааж авах, биедээ хүлээх; *ажлыг бүтээнэ гэж амлах; хэлсэндээ хүрнэ гэж амлах;* 2. бөхийн үгтуул ба амыг хооронд нь ногдуулах; **бөх амлах; амлаж авах** (түүнтэй барилдъя гэж нэр цохож авах); 3. ам зөвшөөх, ам өгөх, тангараглах.

АМЛАХ II хөхт амьтны үр зулзага сая хөх хөхөн сурах; *хүүхэд амлах; хурга амлах.*

АМЛАХ III эд бүсийг энгийн хэмжээгээр дөрвөлжлөн хэмжих.

АМЛАХ IV уулын амаар зорчих, орших.

АМЛАХ V амсарлах, амсартай болгох ,амсар хийх; *аягыг мөнгөөр амлах.*

АМПЕР цахилгааны хүчийг хэмжих хэмжигдэхүүний нэгж.

АМПЕРМЕТР цахилгаан гүйдэл хүчийг хэмжих багаж; *амперметрээр хэмжих.*

АМРАА 1. у р г а м а л өнөд Азийн халуун оронд ургах, жижигхэн жижигхэн цэцэгтэй, гялалзсан ногоон навчит мод; 2. у р г а м а л амраан жимс, хэмжээгээр хэмхийн дайтай, шар ногоон хальстай, дотроо анхилуун үнэртэй, эхүүндүү амтлаг, нялцгайвтар шар жимс.

АМРААХ 1. амрахад хүргүүлэх, амруулах; 2. тайтгаруулах.

АМРАГ маш элэгсэг хайртай хүн; *амраг минь; амраг гэргий; амраг нөхөр;* **янаг амраг** х о р ш . ; *амрагийн сэтгэл төгс;* ☆ **амраг бор** а м ь т а н (өнгө улбар, хүзүү ахар, дуу шингэн, нэгэн зүйл бялзуухай; хядруу бялзуухайнаас бяцхан, эрэгчин эмэгчин хос салахгүй).

АМРАГЛАЛ янаг хайртай, сэтгэлтэй болохын нэр.

АМРАГЛАХ тэсгэлгүй элэгсэх, хайрлах.

АМРАГЛУУЛАХ 1. амраглахын үйлдүүлэх хэв; 2. амраглагдах.

АМРАЛГҮЙ 1. амрахгүй; 2. цуцахгүй.

АМРАЛТ биеийн хүчийг сэргээхээр, албан ажил хийхгүй сул байх үе; *амралтаа ашигтай сайхан өнгөрүүлэх; өдрийн амралт; ээлжийн амралт; зуны амралт;* **амралтын газар** (хүмүүсийг амруулахаар тусгайлан байгуулсан газар); **амралтын чөлөө** (ажилтан ажилчдад жилд нэг удаа олгох чөлөө); **амралтын өдөр** (хууль ёсоор албан ажил хийхгүй өдөр); ☆ **амралт хүжин мод** у р г а м а л (хальс харавтар шар, навч дөрвөн уулзартай, гурван хос алд илүү мод; Америк, Азид ургадаг; түүгээр амралт хүж хийдэг).

АМРАХ 1. ажил хийлгүй байж биеийн хүчийг сэргээх; ажлын дараа амрах; *унтаж амрах;* 2. санаа сэтгэл тайвшрах, тайтгарах; *санаа амарлаа; сэтгэл амрав.*

АМРУУ амны дотоодод цэврүүтэн гарах яр.

АМРУУЛАХ 1. амрахын үйлдүүлэх хэв; 2. амраах.

АМРУУТАХ амруу яр гарах .

АМС бүрхээрт жигнэсэн буюу тогоонд аг шаасан будаа.

АМСАЙХ амсгар болох.

АМСАЛЗАХ амсгар юмны амсас амсас хийх.

АМСАР аливаа дотроо хөндийтэй, зайтай юмны гадаад ам тал; **ам амсар** х о р ш.; *хувингийн амсар; алтан амсартай хундага; тарваганы нухний амсар; ходоодны амсар;* **амсар гарах** (цоорч нээгдэх).

АМСАРДАХ 1. амсрын ойр байх; 2. амсар дээрээс барих.

АМСАРДУУЛАХ амсардахын үйлдүүлэх хэв.

АМСАРЛАХ 1. сав суулга зэргийн юманд амсар гаргах, өөр нэгэн зүйл юмаар амсар хийх; 2. нүх гуу зэрэг юмны амсар дээгүүр явах.

АМСАС: амсас амсас хийх амсгар юмны байн байн хөдлөх.

АМСАХ 1. идээ ундаанаас өчүүхэн бага идэх уух; *идээ амсах; цай амсах; давсы нь амсч үзэх;* 2 .уухыг цээрлэж хэлэх; **архи амсдаг** (уудаг); 3. ш и л ж с э н мөчиг тачиг хүрэлцэх; *туурга дэнгөж амсч байна;* 4. эдлэх, үзэх, биеэр үзэж өнгөрүүлэх; *зовлон амсах; жаргалан амсах;* **амсах орон б и ч и г** (гэрийн баруун өмнө өнцөг).

АМСГА: амсга амсга хийх амсгар юмны үргэлжлэн хөдлөх.

АМСГАНАХ амсгар юмны амсга амсга хийх.

АМСГАР эмсгий шүдгэй, эмсгэр ч гэдэг.

АМСУУЛАХ 1. амсахын үйлдүүлэх хэв; 2. амсахад хүрүүлэх;*цай амсуулах; идээ амсуулах.*

АМСХИЙЛГҮЙ өчүүхэн ч амрахгүй.

АМСХИЙЛГЭХ 1. амсхийхийн үйлдүүлэх хэв; 2. амсхийхэд хүрүүлэх.

АМСХИЙХ түр зуур амрах.

АМТ идээ зэрэг юмны чанар байдлаас хэл аманд мэдэгдэх нь; *тараг исгэлэн амттай; шорвог амт; эхүүн амт; амт сайтай; амт муутай;* **амт шимт** х о р ш.; **амт алдрах** (а. идээ ундааны хуучирч гутаж амт муутай болох); 2. ш и л ж с э н хүний дотор үхширч юманд дур сонирхол буурах; **амт оруулах** (амттай болгох, *чихэр амт оруулах; давсны амт оруулах*).

АМТАГДАХ 1. амтыг мэдрэх; *эхүүн амтагдах; цус амтагдах;* 2. бардах, оморхох саная төрөгдөх; *бяр амтагдаад байна.*

АМТАЙ 1. уран сэцэн үгтэй буюу хэлэмгий аманцар; 2. я р и а онцын чадалтай; *амтай сайн эм; шарханд амтай эм;* 3. ам бүхий юм; *хоёр амтай буу;* 4. харилцан дайсагнах тавилантай; *элээ могойд амтай.*

АМТАЙХАН тааламжтай соньхон амттай; **амтайхан гуа у р г а м а л** (хэмхийн нам, уртавтар бөөрөнхий, хөгнөлөн ургадаг, зүйл бүрийн өнгөтэй, мах нарийн, амт амттайхан, үнэр сайн, үр үлэмж); **амтайхан лууван у р г а м а л** (өнгө улаан шар хоёр зүйл бий. амт амтайхан, үзүүр этгээд шуумгай уртхан, таримал зэрлэг алин ч байдаг).

АМТАРХАГ амт сайтай; *амтархаг идээ.*

АМТАРХАХ 1. амт сайтай юмыг дурлан идэх; 2. ш и л ж с э н ихэд сонирхон дурлах; *амтархан унших; их л амтархан яриулав.*

АМТАРХУУ 1. амтархаг; 2. ямар нэг амттай төсөөтэй; *давсны амтархуу; чихрийн амтархуу юм.*

АМТАТ амт сайтай; **амтат гүйлс у р г а м а л** (цагаан ягаан цэцэгтэй, бутархаг модонд ургадаг, хэлбэр бөөрөнхийвтөр, өнгө шаравтар, амт хүчтэйхэн, дотроо жижиг ястай нэг зүйл жимс); **амтат зүрж у р г а м а л** (дулаан оронд ургах харборын төрлийн олон өргөслөг навчтай, цагаан цэцэгтэй, мөнх ногоон модонд ургадаг, нялцуу нимгэн хальстай, улбар шар өнгөтэй, амт таатай нэг зүйл жимс); **амтат луугийн нүд у р г а м а л** (цагаан цэцэгтэй, хоёр алд илүү өндөр модонд ургадаг, махны нь өнгө луугийн нүд жимснийхээс шар, амт амтайхан нэг зүйл жимс); **амтат зэгс у р г а м а л** (хулсны нам, шүүс нь эмэнд ордог); ☆ **амтат хур** (зохистой цагт нийлүүлэн орсон бороо).

АМТГҮЙ 1. амтлах эрхтэнд мэдэгдэх чанаргүй; 2. бахархал сонирхол үл татах.

АМТЛАГ амттайхан; *амтлаг боов; амтлаг шөл;* **амтлаг тос** (энгөгүй тунгалаг амтайхан шингэн тос; эм саван, чихэр, тэсрэх зай зэргийг найруулахад хэрэглэнэ; угтаа өөхнөөс гаргаж авдаг).

АМТЛАХ 1. юмны амтыг амаар туршин үзэх; 2. идэж уух юманд амт оруулах.

АМТЛУУЛАХ 1. амтлахын үйлдүүлэх хэв; 2. амтлагдах.

АМТТАЙ 1. ямар нэг амт бүхий; *чихэр амттай; гашуун амттай;* 2. сайхан амттай, амт сайтай.

АМТТАЙХАН амт сайтайхан, сайхан амттай.

АМТТАН тааламжтай сайхан амттай зүйлс; бал, чихэр, бурам зэргийг амттан гэнэ; *амттан идээнийхээ дээжийг амраг чамдаа амсуулах гэсэн юм.* 

АМТШИЛ амтших үйлийн нэр; *амтшил олох.* 

АМТШИХ аятай тааламжтайд нь болж байн байн эрэгцэх, нөндэн хэтрэмгийлэх; *авч амтших; идэж амтших; амтшисан хэрээ арван гурав дахин эргэх* с э ц э н. 

АМТШУУЛАХ амтшихын үйлдүүлэх хэв. 

АМУУ будаа тарианы ерөнхий нэр; *амуу будаа; амуу тариа;* ☆ **амуу цэцэг** у р г а м а л (иш өндөр, навч тонхуу ногооны навчирхуу, ур үлэмж, зүйл бүрийн өнгөтэй цэцэг).

АМУУЛАЙ а м ь т а н мөрөн голын цахлай. 

АМУУЛАХ амруулах, амраах.

АМУУШУУЛАХ иштэй тариаг булдах гишгүүлэх зэргээр ишнээс салгах; *тариа амуушуулах.* 

АМЦАЙХ амцгар болох.

АМЦГАР дотогш хамхисан амтай; *амцгар уруултай хүн;* **амцгар ваар** (байшингийн дээвэрт хэрэглэх гэдрэгээ нугалаатай хийсэн ваар). 

АМЬ (АМИН) 1. хүн амьтны бие цогцсын төрөх, өсөх, хувирах, үхэх зэрэг шинжээр илрэх амьд ахуй мөн чанар; **амь аврах** (аминд орох); **амь бие, амь нас** х о р ш.; **амий нь таслах** (алах); **амь сүйдэх, амь сүйрэх, амь хохирох, амь алдах, амь үрэгдэх, амь бусних** (гэнэтийн аюул осол тохиолдон үхэх); **амь хаацайлах, амь хамгаалах** (биеэ арчлах өмгөөлөх, хувиа бодох); 2. аливаа амьд бодисын орших тогтох ахуйн мөн чанар; *амьд цэцэг; амьд цэцгийн баглаа;* 3. амьсгал, амьсгаа; **амь бүтэх** (амьсгал давхцах); **амь тэмцэх** (а. амьсгал бүтэх давчдах, бие өвдөх зэргээр ихэд тэвдэх; б. үйл явдалд ихэд мэгдэх яарч сандрах); 3. эрхэм чухал, нэн хайртай *энэ хүү ч миний амь даа; эцэг нь хүүдээ ч бүр амиа амь* ☆ **амь бөхтэй** (а. хялбар үхдэггүй тэсвэртэй амьтан; б. хялбар урагдаггүй эд эдлэгээ сайтай, яс чанар сайтай; в. хялбар ангижрахгүй зууранги; *өнгөрсөн нийгмийн үлдэгдэл манай ажил дээр амь бөхтэй оршиж байна);* **амь тэвчих** (а. амьтныг алахаа зогсох; б. бусдын амийг хорлуулахгүйн төлөө тэмцэлхийлэх; в. үхэхийг бодохгүй зүтгэх); **амь өрөх** (бэрхшээлтэй үйл явдалд тохиолдож үхэхэд ойр болох); **амь дүйх** (аливаа хэрэгт амь биеийг хайрлалгүй улайн зүтгэх); **амь тавих** (а. үйл хэрэгт маш хичээл гаргаж мэрийн зүтгэх; б. эцсийн амьсгалаа хураах); **амь зуух** (аж төрөн амьдрах); **амь зулбах, амь зулдах, амь зайлах, амь зусатах** (аюултай эмээлтэй зүйлээс зугадан гарах); **амь гарах** (аюул хөнөөлтэй зүйлээс амьд гарах); **амь гүйх** (а. алагдах ялаас хэлтрүүлэхийг гүйх; б. алагдах амьтны амийг хэлтрүүлэхийг хүсэх); **амь таслах** (алах); **амь тасрах** (үхэх); **амь авах, амий нь авах, аминд орох** (а. амьтны амийг аврах; б. амьтныг алах); **амь давирах** (аюултай хөнөөлтэй үйлээс аргацааж ганцаар ангижран гарах); **амь орох** (а. амьтны хэвэл дэх ба өндөгний доторхи үр зулзагын хөдлөх; б. үхэхэд хүрч үхэтхийсэн амьтны сэргэх; в. шингэн юмны бүлээсч халах); **амь татуу** (ашигтай тустай зүйлийг гагцхүү өөрийн бие тийш татах авах, аминч зантай); **амь татах** (а. амь татуу ааш гаргах; б. бусдыг дотночлон ялгаварлаж үзэх); **амин зүрх, амин сүнс** (хамгийн хайртай юм; *миний хүү ч наддаа амин зүрх; ёстой миний амин сүнс дээ);* **амин гол** (а. амьтны нуруу сээрийн ясанд наалдаж байдаг бүдүүн сэлтэр; б. амин зүрх); **амин чухал асуудал** (хамгийн чухал зүйл); **амин судал** (а. гэмтвэл аминд хүрэм чухал судал; б. үйл явдлын чухамхуу ноцтой газар); **амин судлал** (амьд бодисын ухаан, шим ертөнцийн амьдралыг судлах сургаал); **амин судлалч** (амин судлалд мэрэгжсэн хүн); **амин газар** (амьтай холбоотой эмзэг газар); **амин тэжээл** (аж төрөхөд хэрэглэх хөрөнгө юм); **амин гүжрэх** (үхэхээс айж болгоомжлохгүй амь өрж чармайн зүтгэх); **амин зуулга** (амин тэжээл); **амин хувиараа** (хувь хувиараа); **амины** (хувийн, өөрийн); **амины ашиг** (хувийн ашиг); **амины өмч** (амьдралын зайлшгүй хэрэгцээт зүйл, хувцас хунар, орон гэр зэрэг); **амины хэрэг** (а. хувийн хэрэг; б. хүн алсан хэрэг); **амины үг** (маш дотночлох үг); **амины гэрээ** (хувьсын батлан тогтоосон хэлэлцээ); **амиа** (хувиа, өөрийгөө); **амиа бодох** (хувиа бодох); **амиа арчлах** (хувиа хамгаалах); **амиа хаацайлах** (хувиа аргалах); **амиа борлуулах** (хувьдаа оногдсоныг гүйцэтгэх); **амиа хоохойлох, амиа бөөцийлөх, амиа хайх** (а. зөвхөн ганц биеэ бодох; б. амь биеэ арайхан арчлах); **амиа солилцох, амиа арилжих** (ямар нэг юмны төлөө амиа үрэх); **амиа хорлох** (биеэ үхүүлэх); **амиа холбох** (үйл ажилд үхэхээс болгоомжлохгүй, бие сэтгэлээ зориулж чармайн зүтгэх); **амиа солих** (алалцах); **амь амиараа** (тус тусдаа); **хар амиа**

хөөх, хар амиа бодох (зөвхөн хувиа бодох); халуун амь (а. бие; б. нэг гэрийн доторхи хүмүүс): халуун амь, бүлээн цусаа хайрлахгүй (биеэ хайрлахгүй, үхэхээс ч буцахгүй); амь тариа (зүрхний ажиллагааг сайжруулах тариа); амь загас амьтан (умард Америкийн мөрөн нуурт бий нэгэн зүйл загас урт нь 5—6 метр).

АМЬД 1. үхээгүй, амь бүхий; *амьд амьтан; амьд бодис;* амьд байгаль (шим ертөнц); амьдын жин (амьд юмны биеийн жин); *амьд цэцэг;* амьд бодисын хувилах ухаан (амьд бодисын махбодын доторхи химийн үйлдэл явцыг судлах ухаан); амьд бодисын хувилах ухааны (амьд бодисын хувилах ухаанд мэрэгжсэн хүн); ☆ амьд хэл (одоо байгаа хэл); амьд жишээ (бодит баримт бүхий жишээ); амьд сонин (шог үзэгдэл); амьд хүн (идэвхтэй, золбоотой, хөдөлгөөнтэй; *тэр ч түүний дэргэд ёстой амьд хүн).*

АМЬДАЙ I төрөл бус, адил нэртэй хүмүүс бие биесийг ийнхүү дуудна.

АМЬДАЙ II аян явдлын хүний хэрэглэх зайлшгүй хэрэгцээт аар саар юм; бадарчны амьдай (үүрэг).

АМЬДАХ яарах, сандрах, тэвдэх; *зугаацаар явах гэж амьдаж байна би.*

АМЬДРАГЧ амьдарч байгаа нь; *малын ажлаар амьдрагч; усанд амьдрагч; ойд амьдрагч.*

АМЬДРАЛ 1. амь бүхий үе, хувь; амь амьдрал хорш.; 2. амь зуух үйл ажиллагаа; *амин тэжээл, амьдрал сайтай;* 3. нийгэмлэг, хүний үйл ажиллагааны илрэл; *бидний амьдралд үзэгдэж байгаа зүйл; амьдралын зам.*

АМЬДРАХ 1. амь сэргэх; *усанд хийсэн загас дахин амьдрав;* 2. аж төрөх; *амьдрахын төлөө үхэн зүтгэж байна.*

АМЬДРУУЛАГЧ 1. амь оруулагч; 2. амьдрах явдалд тус бологч.

АМЬДРУУЛАХ амьдрахын үйлдүүлэх хэв; амьдрахад хүргүүлэх.

АМЬДУУЛАХ амьдахын үйлдүүлэх хэв.

АМЬЖРАЛ амь зуулга.

АМЬЖРАХ амь зуух.

АМЬЖРУУЛАХ амьжрахын үйлдүүлэх хэв.

АМЬСАХ I санаа сэтгэл харилцан зохилдох; *танайхан чинь айлсаж амьсаад сүрхий байна уу даа?*

АМЬСАХ II амьсгах; *сэрүүн амьсаад байна, бороо орох магадгүй.*

АМЬСГАА амьсгасан хийнээс гадагш гарах дотогш оруулах хувь; амьсгаа хүрэх (гадагш гарах хий юманд тулах); амьсгаа авах (а. хийг дотогш татах; б. түр зуур амарч сэгхийх; *амьсгаа авахуулахгүй шаардан шахав);* амьсгаа татах (а. хийг дотогш татах; б. амьсгаа хураах); амьсгаа орох (а. амьсгаагүй байсан амьтан дахин амьсгаатай болох; б. их халуун байгаад сэрүүвтэр болох); амьсгаа хураах (эцсийн амьсгалаа татаж үхэх); амьсгаа давхцах (амьсгаадах); амьсгааны тоо гүйцэх (нас барах); амьсгааны хэмжүүр (уушигны амьсгах чадлыг хэмжин үзэх багаж).

АМЬСГААДАХ амьсгаа давхцан сүйлхийлэх.

АМЬСГААЛАХ удаанаар амьсгалах.

АМЬСГАЛ 1. амьсгаа; *амьсгалын эрхтэн;* амьсгалын дасгал (амъсгаа задлах сургууль); 2. уур; уур амьсгал, агаар амьсгал хорш.: *өндөр газрын уур амьсгал; далайн уур амьсгал; хуурай газрын уур амьсгал; хаврын амьсгал; хүйтний амьсгал; өндөр газар сэрүүн агаар амьсгалтай; сэрүүн орны хүнд халуун газрын уур амьсгал таарахгүй байна;* 3. шинж төлөв; *муу хэлэх амьсгалтай; яриагий нь ажиглавал сайны амьсгал алга.*

АМЬСГАЛАХ агаарын хийг уушгаар татаж авах; *цэвэр агаараар амьсгалах.*

АМЬСГАЛЛАХ байн байн амьсгал авах.

АМЬСГАХ амьсгалах.

АМЬТАЙ 1. амь бүхий юм; 2. хөрөөгүй бүлээн; *цай амьтай байна;* 3. хөлдөггүй; амьтай ус (харз ус); 4. санаа бодол; нэг амьтай (нэг санаа бодолтой, аминчхан).

АМЬТАН 1. хөдөлж мэдэрч чадах амьд юм; *амьтны аймаг; хүн амьтан; аливаа амьтан хавар болоход баясна;* амьтан судлал (амьтны аймгийг бүхий л талаар судлах ухаан); амьтан судлалч (амьтан судлалд мэрэгжсэн хүн); 2. адгуусан; *гэрийн тэжээвэр амьтан;* 3. олон хүн; *улс амьтан; амьтан ах дүү;* 4. бусад үгтэй нийлж хөөрхийлөх шоодох утгыг илтгэнэ; *хөөрхий амьтан! хэцүүдсэн амьтан; тэнд нэг амьтан зогсож байна;* амьтангүй үе (газар тогтсоны түүхэд амьтан ургамлын үүсэн гараагүй байсан эртний үе).

АН I юмны хагарч гав цав гарсан газар; *газрын ан; хадны ан;* ан гав, ан цав хорш.;

АН II алж ашиглах зэрлэг амьтад; **ан гөрөөс, ан амьтан** хорш..

АН III 1. зан; **ан зан, ан ааль** хорш.; 2. олон нийтийн заншсан хэв суртал.

АНА: **ана мана** харилцан тэнцүү, аль алиныгаа үл дийлэх; *хоёул ноцолдон ана мана байв.*

АНААШ амьтан Африк тивийн халуун оронд оршдог, ац туурайтай, бидэрлэг үнсэн шар үстэй, толгой жижиг, бие богино, сүүл годгор, хүзүү урт, хөл нэн урт, хойт хөл арай ахар, хивдэг гөрөөс.

АНАВАС амьтан өехий шаравтар, бие ноговтор загас; заламгайн бүтсэн байдал бусад загаснаас өөр тул уснаас гарч амьсган чаддаг.

АНАГ хоёр этгээдээс уул шахцасан ам этгээд, явцуу хавцал, мухартаа уудам газар.

АНАГААХ өвчнийг эмчлэн эдгээх; **анагаах ухаан** (өвчнийг судлах, эмчлэх, сэргийлэх, хүнийг эсэнжүүлэх тухай шинжлэх ухаан); **анагаагч уран** (онгоц, суман онгоцны хагарсан, завсар гарсан газрыг нөхөн сэлбэх хүн).

АНАЛИЗ ямар нэгэн бүхэл юмны бүрэлдэхүүн, шинж чанарыг тал бүрээс нь ялган салгаж задлах шинжилгээний арга; *анализ хийх.*

АНАР ургамал исгэлэндүү амттай, хатуу зузаан хальстай, үр мөхлөгт, хүрэн бор өнгийн жимс, сэмбэрүү ч гэдэг.

АНАРХИ эмх замбараагүй, эх захгүй болох байдал.

АНАРХИЗМ өнгөндөө засаг төр хэрэггүй гэдэг үзлээр халхавч хийж пролетарийн диктатур, улс төрийн тэмцэл, шинжлэх ухааны социализмыг эсэргүүцэн, үнэн чанартаа ажилчин ангийг хөрөнгөтний улс төрийн бодлогод захируулах гэсэн жижиг хөрөнгөтний үзлийн урсгал.

АНАРХИСТ анархи үзлийг баримтлагч.

АНАТОМИ бие бүтцийн зүй; *хүний биеийн анатоми; ургамлын анатоми.*

АНАТОМИЧ бие бүтцийн зүйч.

АНАХ I 1. эдгэрэх; *өвчин анаж ялаарьшив;* 2. битүүрэх; *гарсан цав нь анажээ.*

АНАХ II сэрэмжлэх, болгоомжлох, цэнэх; **анах цэнэх; анах отох** хорш.: *анаж байгаад бариа.*

АНАШГҮЙ анах аргагүй, цэнэшгүй.

АНБАРАЙ ургамал илч чийг бүрдсэн газар ургадаг нэг зүйл ургамлын хэлбэр бөөрөнхийдүү үр; том бага янз янз, эмнэлэгт хэрэглэдэг.

АНВАН амьтан далбаа уух загастай адил, бие уухаас урт болоод моголцог нэг зүйл загас, далайд оршино.

АНГА I ац, завсар, салаа, ан гав.

АНГА II: анга сум нумны ацтай сум.

АНГААЛАХ зам хуваан салж тосох эрэх; *ангаалж барих; ангаалж эрэх; ангаалж хоргоох.*

АНГААЛДАХ харилцан ангаалах.

АНГААХАЙ шувууны өндөгнөөс сая дэлбэрсэн зулзага.

АНГАВАЛЗАХ 1. амаа байн байн ангайх; 2. шилжсэн цагийг нөгцөөн сул үг хэлэлцэх.

АНГАГ ундаасамтгай; **ангаг цангаг** хорш.

АНГАГА: ангага ангага хийх ангагар юмны үргэлжлэн хөдлөх.

АНГАГАНАХ ангархай юмны ангага ангага хийх.

АНГАГАР 1. ангайсан ам амсартай; 2. дэмий цаг нөгцөөх зантай.

АНГАЙЛГАХ ангайхын үйлдүүлэх хэв; ангайхад хүргүүлэх.

АНГАЙХ 1. юмны нийлсэн уулзуур салж завсар гарах; *хайч ангайлгаад байна;* 2. юм хагарч ан гарах; 3. ам нээх; *амаа ангайн зогсчээ;* 4. шилжсэн дэмий цаг нөгцөөх; *ангайж суухаар ажлаа хий!*

АНГАЛ ангархай зайтай болсон; *хадны ангал; мөсний ангал.*

АНГАЛЗАХ 1. дуу гарахгүй амаа ангайх; 2. байн байн ангайх; 3. эд юмны уулзар ангас ангас хийх; 4. ангавалзах.

АНГАЛЗУУР I 1. шувууны зулзагын амны завжинд ургасан шар юм; 2. шувууны зулзага буюу ангаахай.

АНГАЛЗУУР II 1. ургамал элсэрхэг говирхог газар ургадаг, өндрөөгөө 30 см. хүрдэг, өнгө цайвар ногоон, босоо хуваагдсан эгнэсэн, ишиндээ өргөстэй, навчин төрөлцог бүрхэвчтэй ургадаг.

АНГАР: **ангар ангар хийх** цаг нөгцөөн дэмий сул үг ярих.

АНГАРАГ мягмар.

АНГАРАЙ ажилгүй, салан задгай.

АНГАРАЙТАХ салан задгай зан байдалтай болох; *ажил хийхгүй ангарайтах.*

АНГАРХАЙ 1. юмны ангайсан газар; *шалны ангархайгаар мөнгө унав;* 2. ш и л ж с э н задгай яриатай; *ам ангархай боловч хэмжээтэй.*

АНГАРХАЙТАХ 1. ангархай болох; 2. ш и л ж с э н дэмий ярих.

АНГАС: ангас ангас хийх ангагар юмны байн байн хөдлөх.

АНГАХ 1. ундаасах, цангах; **ам ангах; ангах цангах** х о р ш.; 2. ус бороо ховордож газар маш хуурай болох; *газар ангах.*

АНГИ 1. нийгэмлэгийн үйлдвэрлэлийн түүхэн тодорхой тогтолцоонд эзлэх сууриараа, үйлдвэрлэлийн хэрэгсэлтэй харьцах харьцаагаараа, нийгэмлэгийн байгуулалд гүйцэтгэх үүргээрээ, нийгмийн баялгийг хуваж авах хэмжээгээрээ, аргаараа нэг ижил нийгэмлэгийн тийм том бүлэг; *ажилчин анги; тариачин анги; ангийн тэмцэл;* 2. аливаа сургуульд нэгэн хөтөлбөрөөр суралцах хэсэг сурагчид; *манай анги жуулчлахаар явна; анги дласан багш; хичээл ангийн эрхлэгч;* 3. сургуулийн хичээл хийх өрөө; *бид ангидаа хичээллэж байлаа;* 4. албан газар, байгууллагын нэгэн хэсэг, салбар, салаа; *ойн анги; шинжилгээний анги;* 5. цэргийн нэгэн хэсэг; *харуул анги; цэргийн анги;* 6. хэсэг бүлэг; *анги бүлэг болох; анги анги болох;* 7. бичиг, уран зохиол, хөгжмийн зохиол, хууль дүрмийн бүлэг зүйл; *хуулийн зүйл анги;* 8. онцгой, тусгай; **анги хүн** (онцгой хүн).

АНГИГҮЙ ангийн ялгавар байхгүй.

АНГИД 1. гадна; *үүнээс ангид;* 2. тусгай; *хонь үхэр хоёр ангидаа өвөлжив;* 3. этгээд, өөр; *ангид зантай; ангид амьтан;* **ангид хас** з у р х а й (тэнгэрийн өмнөд этгээдэд Авиз, Мэргэдийн суудал, Савын яам, Тэнгэрийн зооснь орддын хооронд орших гурван одны орд).

АНГИДАХ салах, ангижрах, ангид болох.

АНГИЖРАЛ хагацал, ангижрахуй.

АНГИЖРАХ I .хагацах, салах, холдох, тусгаарлах; *өөрийн нутгаас ангижран холдов; сайн нөхрөөс ангижрав;* 2. хувилах ухаанд исэлдэх урвалаас гажуу аливаа бодис хүчилтөрөгч хүхэр зэргээс ангижирч үстөрөгчтэй нэгдэх.

АНГИЖРУУЛАГЧ салгагч, тусгаарлагч.

АНГИЖРУУЛАХ ангижрахын үйлдүүлэх хэв.

АНГИЙН I анги гэдгийн харьяалахын хэлбэр; *ангийн ухамсар; ангийн чанар.*

АНГИЙН II ан гэдгийн харьяалахын хэлбэр: *ангийн үс; ангийн буу.*

АНГИЛАГДАХ ангилахын үйлдэгдэх хэв.

АНГИЛАЛ юмыг анги анги болгосон нь; *хэлний ангилал.*

АНГИЛАХ юмыг анги анги, тус тус болгон хуваах.

АНГИЛУУЛАХ 1. ангилахын үйлдүүлэх хэв; 2. ангилагдах.

АНГИНА хоолойн нэг зүйл үрэвсэл өвчин

АНГИНАТАХ ангинаар өвдөх.

АНГИР а м ь т а н асар хүйтэн биш, нэн халуун биш, задгай ус бүхий газар цаг цагаар сэлгэн нүүж нутаглах шувуу; голдуу гал шар өнгөтэй, цагаан толгойтой бий; усанд умбах хөвөхдөө чадамгай; зарим нутагт лам шувуу гэдэг; **ангир нугас** а м ь т а н (бие том, өнгө шар, нэгэн зүйл нугас); **ангирийн хөл** у р г а м а л (янз наанги цагаантай адил, төмс нь улаан цагаан хоёр зүйл бий, чанаж иддэг, амт амтайхан); ☆ **ангир шар** (улбар шар өнгө); **ангир шар уураг** (эхийн хөхний сүү, *ангир шар үүргаа шимүүлсэн ачит эх минь).*

АНГУУЧ анч, гөрөөч.

АНГУУЧИН анчин, гөрөөчин.

АНГУУЧЛАХ анчлах, гөрөөчлөх.

АНД төрөл биш, дотно итгэлцсэн сайн нөхөр; *анд ах; анд дүү; анд зөвлөлтийн нөхөд;* **анд нөхөр** (дотно сайн нөхөр); **анд барих** (төрөл биш хүмүүсийн харилцан барилдан нөхөрлөх); **анд бололцох** (харилцан барилдаж нөхөр бололцох).

АНДАЙЛГАХ андайхын үйлдүүлэх хэв; андгар болгох.

АНДАЙХ андгар II, андгар болох, андгар байх.

АНДАЛДАХ арилжих, солих.

АНДАЛЗАХ андгар II, андгар юмны байн байн хөдлөх байдал.

АНДАХ 1. ташаарах; *чоныг хэн эс андах вэ!;* **андах эндэх** х о р ш.; 2. санаашрах, зовних; 3. буруугаар сэтгэх.

АНДАХГҮЙ сайн мэддэг, ташаарахгүй; *би андахгүй, чамд зааж өгье*

АНДГАЙ тангараг; **андгай тангараг** х о р ш..

АНДГАЙЛАХ амалдах, тангараглах; андгай хийх.

АНДГАНАХ андгар II андгар юмны үргэлжлэн хөдлөх байдал.

АНДГАР I андгай.

АНДГАР II бөгс өгзөг бүдүүн тонтгор.

АНДГАРЛАХ андгайлах.

АНДИС анжис.

АНДЛАЙ харилцан бэр авсан худ; *андлай худ.*

АНДУУ I шингэн юм хийх модон хавчиг.

АНДУУ II андуурамтгай, ташаарамтгай; **андуу эндүү; андуу ташаа** х о р ш.: *андуу харах.*

АНДУУЛАХ 1. ташааруулах; 2, мартуулах, санаашралын нь мартагдуулах; 3. зөвтгөх.

АНДУУРАЛ алдал, эндэл.

АНДУУРАМ маш адил; **андуурам эндүүрэм** х о р ш.; *андуурмаар хоёр хүүхэд байна; андуурам адил юм аль олон.*

АНДУУРАХ эндүүрэн ташаарах; *би тэр хоёрыг дандаа андуурдаг; андуураад өгч орхив.*

АНЖИС тариа тарихад газар хагалах, хөдөө аж ахуйн зэвсэг; морь, мал, трактор зэргээр чирүүлэн хэрэглэнэ; *гар анжис; морин анжис; трактарын анжис;* х у у ч и н **анжисны бариул** (анжисны уланд дээш хандуулан хадаж, газар хагалагч хүний барьж явах иш); **анжисны бөх** (анжисны уланд хадаж, хушуны дээгүүр давуулан дөр торгох (бөгтөр) хэрэглэл); **анжисны дөр** (анжисны дөр дөрвөлж хоёрын хооронд холбох оосор); **анжисны дөрвөлж** (анжисны дөрд уяж, хөллөх оосрыг торгох хөндлөн мод); **анжисны дөш, анжисны шонтуу** (анжисаар газар хагалахад урьдах хагалсан ормыг дагаж явахаар тохируулан бөхийн өмнөх үзүүрт хийсэн мод); **анжисны сээр, анжисны сум** (анжисны улнаас дээш бөхөд холбож хадсан мод); **анжисны толь** (анжисны хушууны онгийн дээд талд хийж, хагалсан шороог унаган дарах төмөр буюу мод); **анжисны ул** (анжисны хошууны онгид углах иш мод); **анжисны хөлөлбөр** (анжисны мал хөллөхөд хэрэглэх тоног); **анжисны чих** (анжисны бөхийн өмнөх үзүүрт хийсэн дөр торгох чагт); **анжисны хошуу** (анжсанд үнхүүлж хийсэн газар урвуулах төмөр); ☆ **анжисны хошуу** з у р х а й (Мэлхийн ордын нэгэн одны нэр).

АНЗ бага сага торгож шийтгэх ял.

АНЗААРАХ юмыг анхааран ажиглаж мэдэх; *би анзаараагүй өнгөрчээ.*

АНЗААРАХГҮЙ анхаарахгүй ,ажиглахгүй.

АНЗААРГА анхаарал, ажиглал, сэрэмж; **анзааргатай** (анхаарал сайтай); **анзаргагүй** (анхааралгүй, сэрэмжгүй).

АНЗААРУУЛАХ анзаарахын үйлдүүлэх хэв.

АНЗЛАХ хөнгөн ял шийтгэх, мал торгож шийтгэх, зовоох.

АНЗЛУУЛАХ 1. анзлахын үйлдүүлэх хэв; 2. анзлагдах.

АНИА I 1. төрлийн доторхи нас ах хүмүүсийн нэрийг цээрлэж хүндэтгэн ийнхүү дууд на.

АНИА II: **чимээ аниа** х о р ш. чимээ амиа.

АНИВАЛЗАХ байн байн аних.

АНИВАСХИЙХ анивхийх.

АНИВХИЙХ нүдийг өчүүхэн зуур аньж харах; *энэ чамайг хуураад над руу нүдээ анивхийв.*

АНИВЧИХ анивалзах.

АНИВЧЛАХ дахин дахин анивчих.

АНИВЧУУР нүдээ байн байн анивчих заншилтай.

АНИГАНАХ анигар хүний анига анига хийх.

АНИГАР нүдний нээлхий нарийн онигор.

АНИГАРХАН баахан анигар.

АНИЙЛГАХ анийхын үйлдүүлэх хэв; анигар болгох.

АНИЙХ анигар болох, онигор болох.

АНИЛДАХ 1. нүд харж чадахгүй байн байн аних; *нойр хүрч нүд анилдаж байв;* 2. олны тус тус аних.

АНИЛЗАХ анивалзах.

АНИЛИН хортой, тосорхог шингэн бодис; үүнээс олон өнгийн будаг найруулан авна.

АНИЛХИЙЛЭХ байн байн аних.

АНИР 1. дуунаас дам дам доргиотон гарах дууриан; **чимээ анир** хорш.; 2. сураг мэдээ.

АНИРГҮЙ 1. нам гүм, чимээгүй; 2. сураг мэдээгүй.

АНИРЛАХ дуунаас дүйвээн дуурианы гарах.

АНИРТ шуугиантай; *анирт гийгүүлэгч.*

АНИРТАЙ 1. дуурианы нүргээн ихтэй; 2. сураг мэдээтэй.

АНИРТАХ дууны анир гарах сонсогдох.

АНИУЛАХ 1. анихын үйлдүүлэх хэв; 2. анигдах.

АНИХ 1. нүдний аньсага хамхих; *нүдээ аньж үгширтэл унтав;* **нүд аних** (а. нүд хамхих; б. зүйрлэсэн нас нөгцөх); 2. яр шархны зэргийн ангайсан дарвайсан юмны битүүрэх; *оголсон шарх аньж байна.*

АНКЕТ харилцах авах тодорхой асуулт бүхий хуснэгт; *анкет бичих.*

АНОА амьтан нэгэн зүйл зэрлэг үхэр, Целебисийн арлын уулархаг газар оршдог, бие бядхан.

АНСАМБЛЬ чуулга, бүрэлдэхүүн, нийц тохироо; **дуу бүжгийн ансамбль** (дуу жүжиг хосолсон уран сайхны бүрэлдэхүүн); **уран барилгын ансамбль** (уран барилгын нийц тохироо).

АНТАГОНИЗМ харш, эвлэрэшгүй зөрчил; *пролетари хөрөнгөтөн хоёрын антагонизм.*

АНТАГОНИСТ харилцан үл эвлэрэх үзэлтэн.

АНТАХ ан гав гарах.

АНТЕН радио долгион дамжуулах хэрэгсэл; *хүлээн авагчийн антен.*

АНУУР хянуур, болгоомжтой, цэнүүр; *юманд их анхаар хүн шүү.*

АНУУРАД зурхай хэлэнцийн ордын дөрвөн одны нэр.

АНУУХАН нас хөгширсөн боловч байдал чадвар тэнхлүүн сайн; *анхаан өвгөн.*

АНХ (АН) тугтам, хамгийн түрүүн, эн тэргүүн; *анх удаа болж байгаа хэрэг; анхны санасан санаа; анхандаа ийм байгаагүй юм; анх намайг суралцаж байхад; анхан шатны сургууль;* **анх сийвэн** (ургамал, амьтны бие махбодын эсийн үндсэн эд, протоплазм); **анхан од** зурхай (тэнгэрийн олон оддыг тэдний гэрэл хэмжээгээр хорин анги болгож хуваасны түрүүчийн зургаан анги дахь оддын нэр, энгийн нүдэнд харагдана; үүний нэгдүгээр ангийн оддыг цөм анхан од гэх бөгөөд бүгд хорь болно); **анхны тэнгэр** (бярманы шашинтны хамгийн их тэнгэр Бишниугийн нэр); **анхны мэдэгдэхүүн** (юуны урьд мэдвэл зохих зүйл; *зоо-мал эмнэлгийн анхны мэдэгдэхүүн);* **анхны шувуу** амьтан (эртний сөнөсөн шувуу, яс үлдэгдэл газар дороос олддог; бие тагтаагийн хиртэй, сүүл нь хорин үе ястай, өд нь сахлаг, амандаа шүдтэй, жигүүртээ гурван салбар хумстай бий); **анхнаас** (эхнээс, угаас; *анхнаасаа сайн хичээх хэрэгтэй байсан юм).*

АНХААРАЛ 1. нэгэн цаг зуурмын хэд хэдэн дурдатгалаас зарим онцгой тодорхой хуран мэдрэгдэх сэтгэхүйн явц; 2. үйл явдалд болгоомжлох хянамж; *анхаарал тавих.*

АНХААРАЛГҮЙ хайхрамжгүй, хянамгай биш, анхаарал муутай.

АНХААРАЛТАЙ болгоомжтой, хянамгай, анхаарал сайтай.

АНХААРАХ ажиглан хянах, үзэн болгоомжлох; *юу болохыг бид их л анхаарч байв.*

АНХААРУУЛАХ 1. анхаарахын үйлдүүлэх хэв; 2. анхаарахад хүргүүлэх.

АНХАЙХ хийх ажилгүй, ариг суух; *ажилгүй анхайн суух.*

АНХДАГЧ эн тэргүүн бий болсон юм; *матери анхдагч, сэтгэхүй хоёрдогч; анхдагч үе.*

АНХДУГААР эхэн, тэргүүн, нэгдүгээр; *анхдугаар дэвтэр; анхдугаар хурал; анхдугаар сар.*

АНХИАН амьтан бие өргөн бөгөөд хавтгай, сүүл нарийн, дээр нь хоёр бяцхан далбаа бий; амьтныг шархдуулбал хорлолтой, их төлөв далайн ёроолд оршдог; мах тэжээлтэй арьсыг боловсруулан элдэж хэрэглэдэг.

АНХИЛАМ сайхан үнэртэй.

АНХИЛАХ их л үнэртэх, сайхан үнэр гарах; *цэцгийн үнэр анхилж байв.*

АНХИЛУУЛАХ 1. анхилахын үйлдүүлэх хэв; 2. анхилахад хүргүүлэх.

АНХИЛУУН анхилам.

АНХИЛУУР: **анхилуур цэцэг** ургамал гүйлсний цэцэгтэй төстэй, анхилам үнэрт цэцэг.

АНХЛАН эхэн, эхнээс, тэргүүн, түрүүнээс; *чи анхлан тэгж байсан биш билүү?*

АНЧ гөрөөч, ан гөрөө хийхэд чадамгай; *анч хүн.*

АНЧИН гөрөөчин; *сайн анчин; анчны эвлэл.*

АНЧЛАХ 1. гөрөөлөх, агнах; 2. бусдын өө сэв эрэлхийлэх; **салхи анчлах** (салхины эеийг дагаж зорчин явах).

АНЬС I алирс.

АНЬС II юмны чухамхүү онцтой газар; *аньсыг олох.*

АНЬСГА 1. нүдний аних нээх дээд доод нимгэн; 2. зовхи; зовхины ирмэг.

АППАРАТ 1. механик байгууламт бүхий хэрэгсэл; *гэрэл заргийн аппарат;* 2. албан байгууллага; *улсын аппарат;* 3. албан байгууллагын орон тоо; *албан аппаратыг хямдруулах.*

АПТЕК эмийн сан өвчтөнд эмчийн зөвшөөрлөөр эм бэлтгэж олгох газар; *эмийн аптек; төв аптек.*

АПТЕКЧ аптекад ажилладаг мэрэгжлийн хүн.

АР I 1. юмны хойд этгээд; *уулын ар; байшингийн ар тал;* 2. өвөр этгээдийн эсрэг тал; *ар нуруу; ар шил;* 3. нүүрийн нөгөө тал; *авдрын ар; толины ар;* 4. өнгө этгээдийн эсрэг тал; *торгоны ар; цаасны ар;* 5. үлдсэн хоцорсон; **ар гэр** (юманд удаан хугацаагаар явсан хүний уг гэр орон; *цэргийн ар гэр);* **ар тал** (а. юмны гадаад, хойд, өнгөний бус тал; б. байлдаан болж байгаа талбараас хойшхи газар; в. цэрэгт үйлчлэх боловч гулалдаанаас гадуур байх байгууллага, цэргийн анги); **арын алба** (цэргийн аж ахуйг эрхлэх газар); ☆ **ар дэвсгэр** (юмны суурь болсон өнгө); **ар зурхай** (сур харвахад, сур өрөх газрын ар этгээдэд нөгөө нэгэн алд хэмжиж гаргасан зураг); **ар хахилаг** амьтан (ногтруушувууны төрөл; цоохор цайвар зүстэй нэг зүйл шувуу).

АР II хээ, зураас, өнгө, ширхэг; *ар гаргаж будах;* **алганы ар** (алганы зурдас); *булигаарын ар; артай цаас;* **усны ар** (усанд салхины дэлдэл буюу газрын аясаар гарсан хунираа).

АР III талбайн хэмжээ, 100 дөрвөлжин метртэй тэнцэнэ.

АРАА I 1. хүн амьтны соёоноос хойших том шүд; **агт араа** (20 наснаас хойш ургах угийн араа); 2. өрөлбө хайч зэрэг хавчих юмны зуух ааг газар; 3. юманд үетүүлэн гаргасан хэрчээс шүд; *дугуйны араа; нэгдүгээр араагаар хөдлөх;* **арааны шүлс гоожих** (а. амтархах зэрэгт шүлс ихээр гарах; б. шилжсэн юманд сонирхон шүлтэж шохоорхох).

АРАА II: **араа тоть** амьтан Америк тивийн халуун орны тоть, өвөгүй, өнгө улаан, хөх, ногоон холимог, өд гоо, махы нь иддэг.

АРААЛАХ 1. юманд араа гаргах; 2. араа шүд ургах; 3. адармаалах; 4. араалдах.

АРААЛДАХ юмын нэгэн дор зэрэглэн орших; *араалдан зогсох; араалдан явах.*

АРААЛДУУЛАХ араалдахын үйлдүүлэх хэв. *араалдуулан өрөх.*

АРААТАН 1. араа бүхий амьтны нийтийн нэр; 2. бусад амьтныг барьж иддэг хэрцгий догшин зэрлэг амьтад; *араатны хаан арслан; араатныг аргаар, адуу малыг уургаар зүйр;* 3. хэрцгий балмад; *араатан фашист.*

АРААХАЙ суйтан.

АРААХАН арайхан, хараахан, үлэмжгүй, цөөхөн.

АРАВ (АРВАН) 1. тооны нэр; *ес дээр нэгийг нэмэхэд арав болно; хүний хоёр гарын хуруу нийлж арав болно; арав арваар; арван арав зуу; арван хоног; нэгдүгээр сарын арван;* **арван зүг** (дөрвөн зүг, дөрвөн зовхис, дээд доод эдгээр арван зүг); **аравны дарга** (арваар хувиарлаж зохион байгуулсан өрх буюу хүний ахлагч); **аймхай хүн арав үхнэ** зүйр (олонтаа); **арван сараа гүйцээсэн аавын хүү** (зориг самбаа сайтай); **арван хуруу тэгш** (юм бүхэн тэгш тэнцүү); **арван хуруу тэгшгүй** (юм болгон тэгш тэнцээргүй); **арван хуруу шигээ мэддэг** (маш нарийн сайн мэддэг); **арван жилийн сургууль** (арван жил суралцах сургууль); **арван хоёр эрхтэн, арван хоёр жил** (Азид эрт цагаас эхлэн он, сар, өдөр, цагийг тоолохдоо хулгана, үхэр, барс, туулай, луу, могой, морь, хонь, бич, тахиа, нохой, гахай ийм арван хоёр амьтны нэрээр нэрлэж хэрэглэсээр иржээ; өдөр шөнийн 24 цагийг арван хоёр жилээр тоолох нь; шөнийн 11 цагаас 1 цаг хүртэл хулгана цаг, 1-ээс 3 хүртэл үхэр цаг гэх мэт болно; үүнд шөнө дунд хулгана цаг, өдөр дунд морин цаг байна); **арав гаруй** (арваас илүү, хориос доош); **арав хир, арав орчим, арав шахам** (арав арай хүрэхгүй); **арван хэдэн** (сарын аравнаас хойших ,хориноос урагшхи өдөр хоног); **арав тав, тав арав** (чамлах санаа, *арав таван малаа өсгөж; тав арав хоног өнгөрөөж);* **арван хар нүгэл** шажин (биеэр үйлдэх: алах, хулгай хийх, буруу хурьцал үйлдэх, хэлээр үйлдэх: худал хэлэх, хов зөөх, дэмий чалчих, хэ-

рүүл хийх, сэтгэлээр үйлдэх: **илүү үзэх, хорлох хөнөөхийг бодох,буруу үзэл**); **арван цагаан буян** (арван харын эсрэг арав); **арван найман там** (халуун найм, хүйтэн найм, орчин хоёр).

АРАВГАНАХ аравгар юмны арвага арвага хийх.

АРАВГАР саравгар, салаа мөчир мэт эрэвгэр сэрэвгэр юмтай; **аравгар саравгар** хорш.; *аравгар бол ааяз л биз* (аман зохиолоос).

АРАВДУГААР дэс тооны аравдахьд тохиолдсон тоо; *аравдугаар сар; аравдугаар анги; аравдугаарт дурьдсан нь.*

АРАВТ арван юмаар бүрэлдсэн зүйлс; *аравтын мөнгө; аравтын цаас;* **аравтын бутархай** (бүтэн тоог 10, 100, 1000 гэх мэтээр хувиарлан жижиг бутархай юмны тоог үзүүлэх тогтолцоо); **аравтын ангилал** (бүх ухааны номыг арван зүйлд хуваах номын сангийн ёс).

АРАГ ачих тээх зүйлийг агуулах, аргал түүх зэрэгт хэрэглэх, бургасыг матаж, үдээрээр боож хийсэн сав; хэлбэр дүгрэг, дөрвөлжин; *аргалын араг; хүнз араг;* ☆ **араг яс** (хүн амьтны биеийн бүтэн хэлхээ яс); **араг орхицоо** (саго бөмбөг).

АРАГЛАХ арагт юм агуулах.

АРАЙ 1. үйлийн байдлыг тодотгоход уул үгийн өмнө тусгай бичнэ, өчүүхэн төдий, ялимгүй бага; *арай хүрэхгүй; арай илүүдэв; арай дутав; арай дээр; арай биш;* 2. үгүйсгэх үгтэй нийлэн дааны, эгээч гэдэг утгатай; *тэр арай ч тэхгүй байх; арай тэх хүн биш;* 3. хугацаатай үйл ажлын хугацаа ойртож шахамдсаныг заахад хэрэглэнэ; *би явах арай болоогүй;* **арай чамай, арай чарай** хорш; *би энэ номыг арай чамай уншиж дуусав.*

АРАЙХАН арай л, хараахан, араахан.

АРАЙХИЙЖ арай чамай; *морио арайхийж олов; арайхийж байж гарч ирэв.*

АРАЛ I мөрөн гол, далай нуурын доторхи усаар хүрээлэгдсэн хэсэг газар; **арал хойг** хорш.; **хагас арал** (гурван талаас усаар хүрээлэгдсэн, нэг тал нь эх газартай нийлсэн хэсэг газар буюу хойг).

АРАЛ II тэрэг чарганд морь мал хөллөхөд бэлдсэн хоёр урт иш мод; *тэрэгний арал.*

АРАЛ III сур жирэм мэтийг дотуур нь оруулан татаж хэлэнд хатган тогтоох дөрвөлжин дүгрэг хэлбэрийн хэрэгсэл; *олонгийн арал; бүсийн арал.*

АРАЛ IV 1. тэнхлүүн чадалтай; *аралтай морь; аралтай сайн* эр; 2. чинээлэг; *аралтай айл.*

АРАЛДАХ тэрэгний дугуй шигдэж, арал нь газардаад явж чадахгүй болох.

АРАЛЖИН тогтворгүй, олон ааштай, авиртай; *аралжинтай амьтан;* аралжаан ч гэдэг.

АРАМЖ ариг гам.

АРАМЖЛАХ ариглах, арвилах.

АРАН төрөлхтөн, харц, **аран хөвүд** (харц овогт хүн).

АРАНГА I адуунд илүү араа шүд ургах өвчин.

АРАНГА II гаранга, эд юманд халтай; *чулуутай газар гутлын аранга.*

АРАНГА III хуучирсан бөөгийн хүүр оршуулсан газар; *бөөгийн аранга.*

АРАНГА IV: аранга цахилгаан олон салаа салбар гарч зүг зүгт цацрах агаарын цахилгаан.

АРАНГА V: аранга шүд илүү шүд давхар шүд, тагнайд ургасан шүд.

АРАНГА VI: аранга төмс зэрлэг төмсний нэг зүйл.

АРАНГА VII: аранга шураг зориуд босгосон маш өндөрлөг зүйл; *нефтийн аранга.*

АРАНГАЛАХ I хувцсаа хайр гамгүй урах.

АРАНГАЛАХ II бөөгийн хүүр оршуулах.

АРАНГАТАХ адуунд аранга өвчин тусах

АРАНДАГ тээр, тээр төвөгшил; *илүү уг толгойд арандаг.*

АРАНДАГЛАХ арандаг болох.

АРАХ орлох, төлөөлөн гүйцэтгэх.

АРВААД 1. тус тус арав; 2. арав орчим, арав шахам; *арваад хүн байлаа.*

АРВААЛЖ амьтан нэгэн зүйл аалз; өнгө шаравтар, хэлбэр шоргоолжирхуу, дөрвөн хэлтэс эвэр хушуутай, толгой дээр нэг иж нүдтэй, найман хөл хоёр туршуултай, явах нь хурдан, хазвал хортой.

АРВАГА: арвага арвага хийх аравгар юмны үргэлжлэн хөдлөх.

АРВАГНАХ 1. айл өрх буюу хүнийг арав арваар зохион байгуулж арван болгох; 2. арванд орох.

АРВАЙ аму тарианы сүрэл түрүүт ургамал, үрээр нь гурил хийх, шар айраг исгэх, охь нэрэх, мал тэжээх зэрэг олон зүйлээр ашиг-

лана: арвай үслэх (арвайн нимгэн хальсыг цэвэрлэх).

АРВАЙЛГАХ 1. арвайхын үйлдүүлэх хэв; 2. арвайхад хүргүүлэх.

АРВАЙЛДАХ олон аравгар юмны харагдах байдал.

АРВАЙЛЦАХ олон аравгар юмны арвайн харагдах.

АРВАЙХ аравгар болох, аравгар байх.

АРВАЛЗАХ аравгар юмны арвас арвас

АРВАНТАА арван удаа.

АРВАС I: **арвас арвас хийх** аравгар юмны байн байн хөдлөх.

АРВАС II бач, бааш; *арвастай хүн.*

АРВАСЛАХ баашлах, бааш гаргах.

АРВИ хэмнэл, арви зан, ялихгүй зан, харам зан; *арви хүн.*

АРВИГҮЙ 1. хямгагүй, гамгүй; 2. хомсхон, арви муутай.

АРВИДАХ хэтэрхий арвин болох.

АРВИДУУЛАХ арвидахын үйлдүүлэх хэв.

АРВИЖИХ арвин их болох; *номын тоо арвижиж байна.*

АРВИЖУУЛАХ 1. арвижихын үйлдүүлэх хэв; 2. арвижихад хүргүүлэх.

АРВИЛАХ хамаа бус хэрэглэхгүй хэмнэх, гамнах; **арвилан хэмнэх** х о р ш.; *олон нийтийн эд хөрөнгийг арвилан хэмнэх хэрэгтэй.*

АРВИЛУУЛАХ арвилахын үйлдүүлэх хэв.

АРВИН аваад барагдахгүй, их хэмжээтэй, элбэг дэлбэг; *арвин будаа авчээ; арвин хүн цуглав.*

АРВИНТАЙ 1. хэрэглэхэд хялбархан барагдахгүй юм; 2. харамч нарийн.

АРВИС мэдлэг; ухаан; **арвис ухаан** х о р ш.

АРВИТАЙ 1. хялбар барагдахгүй, хүртэмжтэй, түгээмжтэй; 2. яльтай, шальтай; **арвитай ч юм биш** (яльтай ч юм биш).

АРВИТАХ улам арвин болох.

АРВИТГАХ арвитахын үйлдүүлэх хэв; арвин их болгох.

АРВИХАН нилээд арвин.

АРВИЧ 1. хэмнэх гамнахдаа бусдаас илүү; 2. ш и л ж с э н хэтэрхий харамч; 3. ааш зан муу; 4. хэтэрхий мэдэмхий.

АРВИЧЛАХ арвич зан гаргах.

АРВУУЛАА юмны хамг нийлж арван тоотой болох; *тэд арвуул ирэв; бид арвуул байна.*

АРГА 1. сүвэгчилсэн ухаан, юмыг хийх бүтээхэд олсон барил; *цаас хийх арга; эм бэлтгэх арга; арга хэрэглэх;* **арга сүвэгчлэх** (арга эрэх); **аргы нь олох** (нэг тийш нь болгох); 2. бусад үгтэй холбон хэрэглэх нь: **арга билэг** (зарим эсрэгцэлдсэн хос юм: нарыг арга, сарыг билэг; халууныг арга, хүйтнийг билэг; эрийг арга, эмийг билэг гэх мэт); **арга бодлого** х о р ш.; **арга барах, аргаа барах, арга барагдах** (а. хэцүү байдалд орох; б. уйтгарлах; в. итгэл түшиггүйдэж гуних гансрах, мухардах); **арга заль** (а. хэрэг явдалд онц тохиромжтой ухаан гаргаж гүйцэтгэх чадвар; б. хуурах, мэхлэх ов жив); **арга мэх** (урхнаар мэхлэх арга); **арга саам хийх** (үйл явдалд хойргошин өөр зүйлээр шалталхийж удаашруулах, өнгөрүүлэх); **арга хэмжээ** (ямар нэг зүйлийг биелүүлэхийн тул хийх үйл ажил; *арга хэмжээ авах; тариаг цаг тухайд нь хураахын тул бүхий л арга хэмжээ авах хэрэгтэй);* **арга чарга** хорш.: **арга явууллага** (арга ажиллагаа); *мэргэн арга; сайн арга; муу арга, буруу арга;* ☆ **арга буюу** (аргагүй; *оройтсон учир арга буюу буцаж ирэв);* **арга эгшиг** (хөгжмийн хөгийн дэс даралдаар; бүтэн хөг, бүтэн хөг, хагас хөг, бүтэн хөг, бүтэн хөг, бүтэн хөг, хагас хөг гэж өгсөөсөн журмаар тодорхойлох зохирол эрэмбийн байгуулал, дэвсгэр хөгийн нэр; *До-арга эгшгийн зохирол эрэмбэ);* **аргын улирал** (нарны эргэлт явдлыг баримталж, цаг улирлыг тоолох зурхай ёсон; Европын он тоолол нь нарны явдлыг гол болгох тул аргын улирал гэнэ); **арга судлал** (шинжлэх ухааны арга буюу шинжлэн судлах аргын тухай сургаал); **арга зүй** (а. ямар нэг зүйлийг хэрхэн хийх арга; *аялгуу судлах арга зүй;* б. юмны ая эвийг сүвэгчлэн олох).

АРГАГҮЙ 1. болох нөхцөлгүй; *өнөөдөр явах аргагүй;* 2. зүй гэж зөвшөөрөх; *аргагүй, аргагүй тэгэлгүй яах вэ; аргагүй чинийх зөв!;* 3. маш чухал; *энэ ном надад аргагүй хэрэгтэй; түүнтэй уулзах аргагүй ажил байна.*

АРГАДАХ 1. хүний санааг засан тайтгаруулах; *уйлсан хүүхдийг аргадах;* 2. ая байдлыг дагуулан найр тавих аргалах; 3. баширлан саймшрах.

АРГАДУУЛАХ 1. аргадахын үйлдүүлэх хэв; 2. аргадах; *аргадуулж байгаа хүн ихэмсэг зантай байв уу?*

АРГАЙ I гөрөөс үхэр мэтийн томхон амьтны шагайн нэр; *үхрийн аргай.*

АРГАЙ II цементтэй ойролцоо, тусгай чулууны зүйлийг найруулан зуурч хийсэн хиймэл чулуу; бодит чулуунаас өөргүй бэх чийрэг, орон байшингийн шал, хэрэм хот цогцлоход хэрэглэнэ.

АРГАЛ үхэр малын хатсан баас; *аргал түүх.*

АРГАЛАХ 1. юмны арга зүй, ая эвийг олох; *амиа арчилж аргалах; эвдэрснийг аргалан засах;* 2. баширлан мэхлэх.

АРГАЛЦАГ төмөрлөгийн зүйлээр цутгаж хийсэн шагай.

АРГАЛЧИН аргал түүгч хүн.

АРГАЛЬ амьтан хонин гөрөөсний эм.

АРГАМАГ угтаа Дундад Азийн цэвэр угсааны морийг ийнхүү нэрлэж байсан, одоо гоёмсог цэвэр байдалтай морийг магтаж ийнхүү нэрлэнэ; *аргамаг хүлэг; аргамаг саарал.*

АРГАМЖ I урт сур, татлага.

АРГАМЖ II хазаарын хацрын өнцөгт татан хадсан төмөр.

АРГАМЖАА морь малыг аргамжих урт сур, дээс, элс; *аргамжаатай морь.*

АРГАМЖИН: аргамжин цэцэг ургамал чавгын модны навч шиг навчтай, өвлийн сүүл хир цэцэглэдэг нэгэн зүйл цэцэг.

АРГАМЖИХ 1. морь малыг идүүлэхээр урт дээс сур мэтээр уяж тогтоох; 2. урсах буюу хийсэх юмыг дээс оосор зэргээр торгож уях; 3. саатуулах, удаашруулах; *түүнийг битгий аргамжаад бай, түргэн яваг!*

АРГАМЖУУЛАХ 1. аргамжихын үйлдүүлэх хэв; 2. аргамжигдах.

АРГАС аргал.

АРГАТАЙ 1. арга бүхий; 2. заль мэх, ов жив ихтэй; 3. зусарч бялдууч.

АРГАХ аргуун болох; **нүд аргах** (нүд хуурайсан хорсох).

АРГАЦАА нөхцөл боломж, арга боломж; *аргацаа байна уу, тун ч алга.*

АРГАЦААЛГАХ 1. аргацаахын үйлдүүлэх хэв; 2. аргацаагдах.

АРГАЦААХ 1. дөнгөж аргалах; *хонийг эвдэрхий хашаанд хашин аргацааж хонов;* 2. арга хийх; *чи эрхбиш аргацааж үзээрэй.*

АРГИАТАХ хөгшрөх зөнтөх зэргээр дэмий аашлах; *тэр гуай ч бүр аргиатчихжээ.*

АРГИЛ 1. хашир догь, бүдүүн томоотой; *аргил хүн;* 2.хүдэр мундаг; *аргил эр;* 3. бүдүүн; **аргил баргил** хорш.; **артил хоолой, аргил дуу,** (эрэгтэй хүний хамгийн бүдүүн хоолой; *аргил хоолойтой дууч);* **аргил жөгжим** (бүдүүн хөгтэй үлээвэр буюу чавхдаст хөгжмийн зэвсэг).

АРГИЛАХ арчлах, хамгаалах, хайрлах .

АРГИМАЛ амьтны нас ахиж чадвар доройтсон байдал; *аргимал болчихсон хүн дээ; аргимал шар; аргимал дуу.*

АРГИХ аргимал болох, хөгшрөх, доройтох.

АРГОН зарлал чимэглэлд хэрэглэдэг өнгө, үнэргүй хий.

АРГУЙ ургамал тариаланд ургана, соёолох үедээ гамхины навчирхуу, аливаа ногооноос эрт ургадаг, исгэлэн ус хийдэг.

АРГУУ (Н) чийг нойтон хэвийн хэмжээнээс багадаж, аглиун, хуурай болсон нь; *агшаасан будаа хэтэрхий аргуу болжээ; аргуун хоол тохиромжгүй.*

АРГУУДАХ хэтэрхий аргуун болох, идэх юмны чийг нойтон нэн багадаж хуурайсах.

АРГУУЛАХ аргахын үйлдүүлэх хэв; аргуун болгох.

АРГУУСАХ аргуун болох.

АРГУУСГАХ аргуусахын үйлдүүлэх хэв; аргуун болгох.

АРГУУТАХ улам аргуун болох.

АРГУУТГАХ аргуутахын үйлдүүлэх хэв; улам аргуун болгох.

АРГУУХАН нилээд аргуун.

АРД I 1. хуучирсан харц олон; 2. иргэн; *хотын ард; малчин ард; ардын хурал;* 3. хөдөлмөрчин олон; *ажилчин, малчин, сэхээтэн монголын ард түмэн; ардын хувьсгал; ардын засаг; ардын хувьсгалт нам; ард иргэн; ард түмэн; түмэн ард; ардын төлөөлөгч; ардын шүүх; Ардын Их Хурал; ардын жүжигчин; ардын аж ахуй.*

АРД II ар I, ар талд, цаад талд, хойд талд; *гэрийн ард; ширээний ард; биеийн ард; самбарын ард;* **хүний ард орох; хүний ард нуугдах** (ажлаас хойш суух).

АРДАГ 1. хал үзээгүй, зовж зүдэрч үзээгүй; *татар. танхил; ардаг морь; ардаг хүн;* 2. ярдаг.

АРДАГДАХ хэтэрхий ардаг болох.

АРДАГЛАХ ардаг зан гаргах.

АРДАГШИХ ардаг болох, зэрлэгших; залхуу болох; *ажил хийхгүй байсаар ардагших муу гэмийг олжээ.*

АРДАГШУУЛАХ 1. ардагшихын үйлдүүлэх хэв; 2. ардагшихад хүргүүлэх.

АРДАЧ ардын үйлс хүслэнг ажил бүтээлд илтгэх чанар; *ардач үзэл; ардач чанар; ардач зохиол.*

АРДИР з у р х а й тэнгэрийн түвшний цагиргийн шадар бүхий Хамтдахын ордын гялбалзсан гурван од.

АРДУУ а м ь т а н зүртэй адилхан, өнгө цагаавтархан нэгэн зүйл гөрөөс.

АРДУУН а м ь т а н бугатай адилхан бөгөөд бага, өнгө шаравтар гөрөөс.

АРДЧИЛАЛ 1. засгийн эрхийг ард түмэн өөрснөө шууд буюу төлөөлөх байгууллагаараа дамжуулан барих төрийн хэлбэр; **хөрөнгөтний ардчилал** (хуурамч хэлбэрийн ардчилал); **нийгэм журамт ардчилал** (хөдөлмөрчин ард түмний жинхэнэ ардчилал); 2. өргөн олны эрх ашгийг хангах аливаа хамт олон буюу байгууллагын арга барил; *намын дотоод ардчилал.*

АРДЧИЛАХ 1. ардчиллыг үндэслэсэн ардын засаг төр байгуулах; 2. ардчилсан ёс тогтоох; **ардчилсан улс** (ардын засагт улс); **ардчилсан засаг төр** (ардчиллын ёст засаг төр).

АРЖГАР буржгар; **аржгар буржгар** х о р ш; *аржгар устэй арьс.*

АРЖИЙЛГАХ аржийхын үйлдүүлэх хэв; аржгар болгох.

АРЖИЙХ аржгар болох.

АРЗ шимийн архийг дахин нэрж гаргасан архи.

АРЗАГА: арзага арзага хийх арзгар юмны үргэлжлэн хөдлөх.

АРЗАЙЛГАХ арзайхын үйлдүүлэх хэв; арзайхад хүргүүлэх.

АРЗАЙХ 1. арзгар болох; *шүд нь арзайж байв;* 2. ш и л ж с э н хүний бие ая тавгүй болон зарсхийх жишүүцэх; *бие арзайх.*

АРЗАЛЗАХ арзгар юмны арзас-арзас хийх.

АРЗАС: арзас арзас хийх арзгар юмны байн байн хөдлөх.

АРЗАСХИЙХ ямар нэгэн юмнаас болж бие ширвээтэх; *сочиж бие арзасхийв.*

АРЗВАЛЗАХ арзалзах, арваганах.

АРЗГАЙ арсгай, арзгар; *арзгай шүдтэй; арзгай хашаа.*

АРЗГАНАХ 1. арзгар юм арзага арзага хийх; 2. ш и л ж с э н олон амьтан хүний нэгэн газар бужигналдан үймэх; 3. хүний бие ая тавгүй болон зарсхийх; *бие арзганах.*

АРЗГАР аливаа юмны эрвэн сэрвэн буюу үрчгэр барзгар; *арзгар үстэй; арзгар даавуу; арзгар хөлтэй амьтан.*

АРИАДУУ а м ь т а н эр ардуу.

АРИАН ууль шувууны нэг зүйл.

АРИГ I арви гам, **ариг гам** х о р ш.; *юмандаа ариггай хүүхэд.*

АРИГ II: **ариг суух** зүгээр суух, дэмий суух.

АРИГ III цэвэр тунгалаг, цэнгэг; *ариг ус.*

АРИЛАМ нэг хормыг буюу нэг секундийг нэг тэрбум хуваасны нэг.

АРИЛАХ 1. үгүй болох; *гарт наалдсан бэх арилав;* 2. зогсох; *бороо арилжээ;* 3. цэвэрших, *хор хөнөөл; өвчин тахал арилав.*

АРИЛГАХ I арилахын үйлдүүлэх хэв; 2. арилахад хүргүүлэх.

АРИЛЖАА I юмыг юмаар харилцан солих; **арилжаа наймаа** х о р ш..

АРИЛЖАА II: **арилжаа хатир** морины явдал, хатир жороо хоёрын хоорондох зөөлөн ялгуумаар явах явдал; *арилжаа хатиртай морь.*

АРИЛЖААЛАХ I харилцан арилжаа хийх.

АРИЛЖААЛАХ II морины арилжаа явдлаар явах.

АРИЛЖИХ I юмыг харилцан солилцон өгч авах; *тэмээ морь хоёроо арилжив;* **амиа арилжих** (а. бие биеийг алах; б. ш и л ж с э н байлдах жанчилдахад байдаг хүчээ шавхан тэмцэх); **буцц арилжих** (малын хашаа буцц бохирдож тохиромжгүй болоход сэлж буух).

АРИЛЖИХ II арилжаалах II

АРИУЛАХ ариун болгох; *үнэртнээр ариулах.*

АРИУН 1. буртаггүй, цэвэр; *ариун цэвэр;* **ард иргэдийн нийгмийн ариун цэвэр** (эрүүл мэндийг хамгаалан сахих); *ариун цэврийн эмч; хотын ариун цэвэр; хувийн ариун цэвэр; үйлдвэрлэлийн ариун цэвэр;* 2. шудрага, үнэнч, *ариун санааны үр; ариун хөдөлмөр;* 3. машид хүндэтгэх, онцгой чухаг, нандин, нарийн; *эх орноо хамгаалах ариун үүрэг;* **ариун заарт цэцэг** ургамал (уян иш салаатай, малигаа цэцгэрхүү цэцэгтэй, дөрвөн хэлтэстэй, шар юм уу цагаан өнгөтэй, сайхан үнэртэй цэцэг).

АРИУСАХ ариутах.

АРИУСГАХ ариутгах.

АРИУТАХ ариун болох, цэвэрших.

АРИУТГАЛ ариун болгох үйл.

АРИУТГАХ 1. ариун болгох, цэвэрлэх; *халдварт өвчтөний хувцсыг ариутгана;* 2. шилжсэн хор хөнөөлтэй зүйлийг үгүй болгон устгаж цэвэрлэх.

АРИУТГУУЛАХ 1. ариутгахын үйлдүүлэх хэв; 2. ариутгагдах.

АРИУТГУУР ариутгах зэвсэг, юм.

АРИУХАН маш ариун.

АРИФМЕТИК тоо бодлого.

АРИФМОМЕТР тоо бодлогын машин.

АРЛАХ I 1. юманд артай болгох; *зургийн гуу арлах.*

АРЛАХ II арлах, орлох.

АРЛАХ III юмны ар талаар явах; *уул арлах.*

АРМАА баруун монголд том жад сэлэм мэт зэвсгийг ийнхүү нэрлэнэ.

АРМАГ: армаг тармаг энд тэнд, тархай, сийрэг; *армаг тармаг модтой уул.*

АРМАНА амьтан Африк тивийн халуун орны цэнгэг усны сангаар орших, ац туурайтай, зузаан арьст гөрөөс; хүнд нь 2—3 тонн, уртаашаа 4,5 м. өндөөрөө 1,5 м. хүрдэг; усанд шунгамтгай, хушуу банхгар, толгой занхгар, бие балхгар нэг зүйл гөрөөс.

АРМАХ хамах тармах.

АРМИ 1. улсын зэвсэгт хүчин *зөвлөлтийн арми;* 2. хэд хэдэн корпус, дивизээр бүрдсэн цэргийн том анги нэгдэл; **армийн генерал** (цэргийн цол).

АРСАЙЛГАХ арсайхын үйлдүүлэх хэв; арсагар болгох.

АРСАЙХ арсгар болох.

АРСГАР арзгар, сэрзгэр, сиймхий; *арсгар хад; арсгар даавуу.*

АРСЛАН амьтан 1. мигуйн аймгийн том араатан; толгой том, сүүл урт, шаравтар халцгай үстэй, эрэгчин нь урт сагсгар дэл зогдортой; 2. аймаг ба улсын наадамд анх түрүүлсэн бөхөд олгох цол; *аймгийн арслан; улсын арслан;* ☆ **арслан заан** амьтан маш том биетэй, дүрс байдал заантай адил, урт үстэй, том тахир соёотой, нэг зүйл сөнөсөн амьтан; газраас сэг нь олддог; хуучин толь бичигт мөсч хулгана гэж нэрлэсэн бий.

АРТЕЛЬ үйлдвэрлэлийн багаж хэрэгслийг нийгэмчлэн нэгдсэн иргэний үйлдвэрийн социалист хэлбэр; *хөдөө аж ахуйн артель; гар үйлдвэрийн артель; артелийн дүрэм.*

АРТЕРИ зүрхнээс гарсан цусыг бүх бие махбодид тараах судас.

АРУР ургамал чийгэрхэг дулаан оронд ургадаг нэгэн зүйл модны үр; дотроо ястай, ясны дотор тослог идээтэй, амт эхүүн, хэлбэр гонзгойвтор бөөрөнхий, хоёр үзүүр нь шөвгөр.

АРУУ: аруу таруу армаг тармаг.

АРУУХАН 1. оюун ухаан хурц сэргэлэн авхаалжтай; 2. зүс царай гоо сайхан; 3. хоёр юмыг зэрэгцүүлэн жишихэд нэгий нь нөгөөгөөс дээр гэхэд; *энэ түүнээс аруухан.*

АРХАГ I оршиж тогтсон хууч өвчин; *архаг мэнгэр; архаг хэрэх өвчинтэй; сочмог өвчин архаг болох.*

АРХАГ II торгоны хоёр захын ирмэг.

АРХАГ III хүч их, том янхигар; *архаг чадалтай; архаг биетэй.*

АРХАД шажны ёсонд нясванисыг тэвчсэн хүн; *архадын үрийг олох.*

АРХАЙ I тархай; **архай тархай** хорш.; энд тэнд, хэсэг хэсэг.

АРХАЙ II араахай.

АРХАЙХ архгар болох.

АРХГАР юмны эв хавгүй том, янхигар; **архгар дархгар** хорш..

АРХЕОЛОГИ эртний судлал.

АРХЕОЛОГИЧ эртний судлаач

АРХИ согтуурах унд, охьтой унд; **архи дарс** хорш.; *архинаас гарах; архинд өрөх; улаан архи; хар архи; монгол архи; тогооны архи; шимийн архи; нэрмэлийн архи; архи нэрэх;* **архины үйлдвэр** (архи боловсруулах газар); **архины луу** (а. архи агуулах, бургасаар сүлжиж хийсэн нэгэн зүйл сав; б. архинд хэтэрхий шунаатай хүн).

АРХИВ хуучин бичиг данс хар, түүнийг хадгалах газар; *Улсын архивын төв газар; Гэгээрлийн Яамны архив; хувийн архив.*

АРХИДАХ олноор нийлж архи уух.

АРХИЛАН а м ь т а н арслангийн нэг зүйл.

АРХИРАХ араатан амьтны бүдүүн дуугаар хүрхрэн ярдаглах; *нохой архирч байна; арслан архирах.*

АРХИЧ (ИН) архинд маш дуртай, ямагт ууж согтуурах хүн.

АРЦ у р г а м а л агарын намын мөнх ногоон шилмүүст модруу, шилмүүс нь зүү шиг шовх, анхилуун үнэрт жимсгэнэтэй, эмэнд ордог, зарим газар архи нэрэхэд хэрэглэдэг; **арц бургас** у р г а м а л (ой харууд ургана; улаан голтой, дүгрэг зузаан навчтай хандгай иддэг, нумны дүгрэг ба урам хийдэг).

АРЦАЛДАА зөрөлдөө, маргалдаа.

АРЦАЛДАХ зөрөлдөх, маргалдах.

АРЦАХ хэдэрлэн маргах, зөрөх, гэдрэглэн хойргоших.

АРЦУУЛАХ 1. арцахын үйлдүүлэх хэв; 2. удаах түдээх.

АРЧ арчаа.

АРЧАА юмыг аргацаах арга чадвар; *арчаатай; арчаагаа алдах.*

АРЧААГҮЙ арга чадваргүй, ажилгүй; *арчаагүй болох; дааны ажилдаа арчаагүй.*

АРЧААТАЙ арга чадвартай, ажил сайтай; *ажилдаа арчаатай.*

АРЧГАР үрчгэр хорчгор.

АРЧИЙЛГАХ арчийхын үйлдүүлэх хэв; арчгар болгох.

АРЧИЙХ арчгар болох.

АРЧИЛ: арчил бургас у р г а м а л арц бургасны нэг зүйл.

АРЧИН: арчин бялзуухай а м ь т а н дулаан оронд байдаг шувуу; хөхөөний нам, өд жигүүрийн өнгө үзэсгэлэнтэй, бие бяцхан нэг зүйл шувуу.

АРЧИХ 1. арчуур мэтээр шүргүүлэн үрж арилгах, зүлгэх, цэвэрлэх, *ширээний тоосыг арчив; гараа угаагаад арчуурт арчив;* 2. тариаланд хольцон ургасан зэрлэгийн зүйлийг арчуур гэдэг зэвсгээр тасчин арилгах; ☆ **арчих самбар** (бичсэн бичгийг арчиж арилгаад дахин бичихэд болохоор тохируулан үйлдсэн нэгэн зүйл самбар).

АРЧИЛГАА хайрлаж санаа тавих үйлийн нэр; *арга арчлагаа; арчлагаа маллагаа.*

АРЧЛАХ 1. харгалзан хамгаалах буюу дэмжин тэнхрүүлэх; *тарьсан цэцгийг мөндрөөс арчлав; ядарсан малыг арчлан тэнхрүүлэв;* 2. хайрлан гамнах; *улсын хөрөнгийг нудний цөцгий мэт хайрлан арчлах хэрэгтэй.*

АРЧЛУУЛАХ 1. арчлахын үйлдүүлэх хэв; 2. арчлагдах; *зудад эцсэн мал арчлуулахад хүрнэ.*

АРЧУУЛАХ 1. арчихын үйлдүүлэх хэв; *хүүхэд нь гар нүүрээ арчуулав;* 2. арчигдах.

АРЧУУР 1. юмыг цэвэрлэх, арчих, зүлгэхэд хэрэглэх эд бүсийн зэрэг зүйл; *нүүр гарын арчуур; нусны арчуур; аяганы арчуур;* 2. тариаланд хольцон ургасан зэрлэг өвс зэргийг тасчин арилгахад хэрэглэх зэвсэг.

АРШ аглагт оршиж шажны ёсны бясалгал даяан хийх хүн; ☆ **арш шувуу** (тогоруу шувууг яруу найрагт ийнхүү нэрлэнэ); **аршийн гар** у р г а м а л (дулаан оронд ургадаг шүүсэрхэг бүдүүн иштэй, өргөст ургамал); **аршийн чавга** у р г а м а л (цэцэг улаан, гурван зуун жилд нэг удаа цэцэглэнэ; есөн зуун жилд нэг удаа жимс ургана, жимсийг төмрөөр огтолбол хүчтэй амттай, хумсаар огтолбол төгс амттай болно гэдэг); **аршийн жимс** у р г а м а л (найм есөн тохой өндөр модтой, луугийн нүдэн модны навчирхуу бөгөөд жижигхэн навчтай, хонгорцоглон ургах жимстэй, нитоор мэт том, жимс нь амтайхан); **аршийн алга** у р г а м а л (хэлбэр гарын алга мэт, аршийн ургамлын нэг зүйл); **аршийн нудрага** у р г а м а л (хэлбэр гонзгой бөөрөнхийвтөр зангидсан гарын адил, аршийн ургамлын нэг зүйл).

АРШААН 1. ямар нэгэн өвчин эмгэгийг анагаах чадал бүхий эрдэст ус; *халуун аршаан; хүйтэн аршаан; дотрын аршаан;* **аршаан эмнэлэг** (рашаанаар эмчлэх газар); 2. шажны ёсонд бузар түйтгэрийг ариутгах чадал оршуулсан гэдэг ямар нэг зүйл; *аршаан үрэл; аршаан хүртэх; бумбатай аршаан;* 3. бодоо өвчнийг цээрлэсэн нэр.

АРШААНТАХ бодоо өвчнөөр өвчлөх.

АРШИН дээр үед оросын хэрэглэж байсан уртын хэмжүүр, 0,71 метртэй тэнцэнэ.

АРШЛАГ: аршлаг цэцэг у р г а м а л өнгөөр сайхан цэцэг, хавраас намар хүртэл цэцэглэнэ.

АРЬС I 1. хүн амьтны биеийн гадуур бүрхүүл хөрс; *гарын арьс; ямааны арьс;* **гангийн** арьс (ганд дүрж элдсэн арьс); *ангийн арьс; арьс элдэх; арьс өвчих;* **арьс мах; арьс, хөрс** х о р ш.; **арьсны өвчин** (зөвхөн арьсанд гарах өвчин); **арьс өнгөний өвчин** (бэлгийн эрхтнээр дамжин үүсэх яр, тэмбүү, заг хүйтэн зэрэг халдварт өвчин); 2. алмарад алимны зэрэг томхон жимсийн гадуур бүрхсэн хальс; *бэрсүүт жүржийн арьс;* ☆ **арьсан бөдөн а м ь т а н** (бөдөн шувууны нэг зүйл).

АРЬС II арьсны өнгө, үсний онцлог, толгойн хэлбэр, биеийн байгуулалт зэрэг бие цогцсын шинж чанарыг харгалзан, хүн төрөлхтнийг төсөө тоймоор ялгаварласны нэгэн бүлэг; **арьсны онол** (арьсны өнгөөр ялгаварлан дорамжлох хөрөнгөтний үзэл).

АРЬСДАХ мал өвчихөд хөрсий нь халчин эсгэх.

АРЬСЛАХ 1. юмыг арьсаар бүрэх; 2. арьсдах.

АРЬСТАН арьс нэгтэн; *хар арьстан; цагаан арьстан.*

АРЬСУУ а м ь т а н тогоруу шувууны нэг зүйл.

АСААГУУР тамхи асаах цахиуртай буюу шатахуунтай хэрэгсэл.

АСААЛГА асаадаг юм.

АСААЛГУУР асаагуур.

АСААХ I асаахын үйлдүүлэх хэв; *гал асааж суув; лаа асаалаа.*

АСААХ II х у у ч и р с а н асар хүндэтгэвэл зохих хүний хувцаа өмсөхийг ийнхүү нэрлэж байв; *баринтгаа асаах.*

АСАГ I тэмээ үхрийн зэрэг амьтны хөлийн үест шар ус, цус хуралдан доголох өвчин.

АСАГ II хуучин бичиг сударт асуу гэхийг асаг гэж бичсэн байдаг.

АСАГДАХ асуугдах.

АСАГТАХ морь малд асаг өвчин тусах.

АСАМТГАЙ асамхай, наалдамхай, халдамтгай, авирамтгай.

АСАМХАЙ хялбар асдаг юм.

АСАНГИ тооны нэр, ингүмэл; *асанги галав.*

АСАР I 1. бүс даавуугаар байшингийн дүрстэй дөрвөлжлөн хийсэн нэгэн зүйл оромж; 2. байшин буюу хаалга хэрмийн дээр барьсан саравчит давхарлаг.

АСАР II маш, тун; *асар их; асар догшин.*

АСАРЛАХ майхны зэрэг оромжийн ваадан сөхөж, модоор тулган татан тэлж уях; *халуунд майхнаа асарлав.*

АСАХ I 1. ноцох, гал гэрэл гарах; *гал асч байгаа газар: чийдэн асав;* 2. шатамхай; асах хий (шатах хий).

АСАХ II 1. өндөр юм өөд авиран гарах; *мөдонд асах; хаданд асах;* 2. зөөлөн унгарил юмны наалдан тогтнох; *дээлэнд өвс асах; хөвөн асчээ;* 3. хайрлан эрхлүүлэх хүнд хүүхэд авиран эрхлэх буюу улмаар ташууран хэтрүү зан байдал гаргах; *миний хүү битгий асаад бай, аав нь ядраад байна;* 4. бусдад хүрч халдах; *ах захдаа асах.*

АСГА уул, зав, хавцгай зэрэг газарт хэсэг хэсгээр овооролдон орших сул хад чулуу; *асгатай газар;* **хад асга х о р ш . .**

АСГАР худаг усанд мал услах зэрэгт хальсан, асгаснаас тогтсон шалбаа ус; *худгийн асгар.*

АСГАРАХ шингэн буюу үйрмэг юм хальж цалгин гоожих, хаягдах, гээгдэх, ихэд асгах; *гантай ус асгарах; их халуунд хөлс асгарлаа; хүүдийтэй будаа асгарч явна; бороо асгарах; нулимс нь асгарав.*

АСГАРТАХ худгийн орчинд асгар тогтох.

АСГАРУУЛАХ 1. асгарахын үйлдүүлэх хэв; 2. үргэлжлэн асгарах; *нулимс асгаруулах.*

АСГАХ I 1. шингэн буюу үйрмэг зүйлийг сорох, гээх, зайлуулах, хаях; *хувинтай ус асгав; аягатай цайгаа алдаж асгав; шүүдайтай төмсийг асгав;* 2. цалгих, асгарах; *савтай шөл халин асгаж байв; бороо асгалаа; нулимс асгав.*

АСГАХ II бичиг сударт асуух гэхийг асгах гэх нь бий.

АСГИХ бага зэрэг занчих.

АСГУУЛАХ асгахын үйлдүүлэх хэв.

АСЛИС з у р х а й тэнгэрийн бүслүүрийг оргилон орших Угсаагийн хүн ордын найман одны нэр.

АСМАГ агталсан эр гахай.

АСМАДАХ урьд үзээгүй сураагүй юмыг хийх үйлдэхэд ээ эвийг олохгүй ядах.

АСМАН 1. хожим хөнгөлсөн буюу уулаасаа дотор имтэй бөгөөд хөнгөлж болохгүй эрмал; *асман шар; асман бух;* 2. үзэж сурсан юмгүй; *сурсан ажилгүй асман хүн; асман лам* (ном уншлага мэдэхгүй лам).

АСМАРАХ асман болох.

АСПИРАНТ эрдмийн зэрэг хамгаалахаар эрдэм шинжилгээний байгууллага буюу дээд сургуульд судлагаа хийж суралцаж байгаа хүн.

АСПИРАНТУР аспирант хүний суралцах газар.

АСРАГЧ асардаг хүн; *хүүхэд асрагч; өвчтөн асрагч.*

АСРАЛ асрамж.

АСРАЛГҮЙ асрах, хайрлах, өрөвдөх сэтгэлгүй.

АСРАЛТ бусдыг асрах сэтгэлтэй; *асралт дүүгийн амрыг эрэн захидал бичив.*

АСРАЛТАЙ асрах, өрөвдөх сэтгэлтэй.

АСРАМЖ асрах үйлийн нэр; хамгаалал.

АСРАМЖЛАХ ядуу дорой амьтныг тэтгэн тэнхрүүлэх.

АСРАНГУЙ асрах сэтгэл төгс.

АСРАХ арчлах, хамгаалах, харгалзах, сувилах зэргээр үйлчлэх; *эхийгээ асран сувилав.*

АСРАХУЙ I амьтныг нийтээр тэгш жаргуулахыг хүсэх сайн санаа.

АСРАХУЙ II тооны нэр 52 оронтой тоо; арван их хүчин нүдэн нийлж нэг асрахуй болно; **их асрахуй** (53 оронтой тоо).

АСРУУЛАХ 1. асрахын үйлдүүлэх хэв; 2. асрагдах.

АССАМБЛЕЙ олон улсын улс төрийн байгууллагын гишүүдийн ерөнхий хурал; *Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей.*

АССИГНОВ авцгаах хуудас.

АСТРОНОМИ од судлал.

АСТРОНОМИЧ од судлалч.

АСТРОСКОП огторгуй дахь одон гаргийг олох тэнгэрийн дуран.

АСТРОФИЗИК одон бодис зүй.

АСУУГДАХ асуухын үйлдэгдэх хэв.

АСУУДАЛ 1. туурвиж шийдвэрлэвэл зохих үйл, ажил, хэрэг, зүйл; *хүмүүжлийн асуудал; хотыг цэцэрлэгжүүлэх асуудал; хуралд хэлэлцэх асуудал; хувийн асуудал;* 2. асуулт; *над нэг асуудал байна.*

АСУУЛГАХ 1. асуухын үйлдүүлэх хэв; 2. асуугдах.

АСУУЛТ асуух үйлийн нэр; *асуулт асуух; асуулт хариулт;* **асуултын хуудас** (хариу тодорхойлуулахаар зориуд үйлдсэн асуулт бүхий хүснэгт ба хуудас); **асуултын тэмдэг** (асуух өгүүлбэрийн эцэст хэрэглэх нэг зүйл тэмдэг).

АСУУРЬ шажны ёсонд эх болсон зургаан зүйл амьтны нэг, тэнгэрсийн дайсан тэнгэрийн нэр; **асуурийн чивхэн** (охь архи); **асуурийн цус** (сармисын өөр нэр).

АСУУХ 1. юмыг мэдэж авахын тулд хүнд асуулт тавих лавлах; *би танаас нэг юм асууя; намайг хүн асууж ирэв үү?; асуух өгүүлбэр;* 2. мэнд сайныг мэдэх; *мэндийг асуув; эжийнхээ биеийг асууж байна гээрэй; өвчтэй хүний биеийг асуух.*

АСФАЛЬТ цардас.

АСФАЛЬТЛАХ зам, гудамж, талбайг цардах.

АСХАН I 1. шулуун, цэх; *асхан үүрга;* 2. ойр дөт; *асхан зам.*

АСХАН II баруун монголд орой үдэш гэхийг ийнхүү нэрлэдэг; *би өнөөдөр асхан явна.*

АТ (АН) таваас дээш насны агталсан эр тэмээ; *атан тэмээ.*

АТАА I бусдын давууд мөчөөрхөн тэчьядах сэтгэл; *атаагаар хорлоход хүрчээ;* **атаа жөтөө; атаа тэмцэл** х о р ш.

АТАА II бөөгийн шажны ёсны онголж шүтээн болгосон морь.

АТААРХААЧ атаархдаг хүн.

АТААРХАГ атаархамтгай.

АТААРХАЛ атаархах сэтгэл.

АТААРХАМТГАЙ атаархуу.

АТААРХАХ бусдын давуу зүйлд тэчьядах; *атаархсан байдалтай, хойноос нь харав.*

АТААРХУУ бусдын давуу сайнд тэсч ядах зантай; *атаархуу хүн.*

АТААТАН атаа бүхий этгээд; *атаатан дайсан .*

АТААЧ атаархагч.

АТАВЧ 1. морь малд тохом тохоход хэрэглэх тусгай хэрэгсэл; 2. тэмээний тохшийн дөрөөний холбоо; *атавчтай тэмээ.*

АТАК дайсан этгээдийн өмнөөс хүчтэй эсэргүүцэн довтлох; *морин атак; атакад орох.*

АТАКЛАХ дайсанд довтлон орох.

АТАКЛУУЛАХ 1. атаклахын үйлдүүлэх хэв; 2. атаклагдах.

АТАЛ бөгөөтөл, байтал; *хамаагүй атлаа оролцов; бий атлаа үгүй гэв.*

АТАЛДАХ могой мэтийн амьтны аталзан хөдлөх.

АТАЛЗАХ өт хорхой зэргийн амьтны атиран сунан хөдлөх.

АТАЛЦАХ загасны хос нийлж түрс орхих.

АТАР эдлэгээ хал үзээгүй; 1. хагалварлагдаагүй эдлэгдээгүй эрүүл бүтэн газар; *атар газар; атар хагалах;* **атар өвс** (хүн малд гишгэгдээгүй соргог өвс ногоо); 2. хүний ажил хөдөлмөрт дасаагүй танхи; **атар танхи** х о р ш. 3. эдлэгээнд сайн сурч дасаагүй мал адгуус; *атар мал; атар зээрд.*

АТАРДАХ хэтэрхий атар болох.

АТАРЖИХ атар болох; *атар ба атаржсан газрыг эзэмшин эдлэх.*

АТАРЖУУЛАХ 1. атаржихын үйлдүүлэх хэв; 2. эдэлж байсан газрыг удаан хугацаагаар амруулах.

АТАРЛАХ ажил явдалд авад хөдлөхгүй, хойргоших, хойш суух; *биеэ атарлах.*

АТАРЛУУЛАХ 1. атарлахын үйлдүүлэх хэв; 2. атарлагдах; атар байлгах.

АТАРШИХ атар шинжтэй болох; 1. тариалангийн газар эдгэрч чийрэгших; *газар атарших;* 2. хүн малын удтал ажилгүй сул чөлөөтэй явж, ажил үйлдвэр, эдлэгээ явдалд төсөөрч атар болох; *удаан хугацаагаар амарсан биш, бие атаршчихжээ.*

АТАРШУУЛАХ атаршихын үйлдүүлэх хэв; атаршихад хүргүүлэх.

АТГА 1. нэгэн гарын алга хуруур хумьсны доторхи зай дүүрэн хэмжээ; *атга давс;* 2. ш и л ж с э н өчүүхэн, бага (чамласан янзтай); *атга давс авсан;* **атга чимх** х о р ш..

АТГААЛ дал богтос хоёрын хоорондох чөмөг яс.

АТГАГ 1. далд үзлийг баримталсан дотоод санаа; 2 .сэтгэлд сэжиг төрж таслан чадахгүй тээнэгэлзэх санаа; 3. дотор өшөө хорсол өвөрлөсөн санаа; *атгаг санах; атгаг авах,* (дотроо хорсох гомдох зэргээр нийцгүй муу санаа агуулах); **атгаг тоо** (гагцхүү биедээ хуваагдах тооны ерөнхий нэр).

АТГАГГҮЙ хар хоргүй, цагаан санаатай.

АТГАГЛАХ дотроо сэжиг хорсол атуулах.

АТГАЛАХ байн байн, дахин дахин атгах

АТГАМАЛ 1. гарын дөрвөн хуруур дотогш нугалан атгаж авсан юм; 2. гарын хурууд бэртэх, гэмтэх зэргээр атган эдгэрсэн.

АТГАНА у р г а м а л гогодын үндэс, сэвлэг нь таананых шиг, амт амтайхан, хэлбэр мангирын үндэс шиг бөгөөд муруй, өнгө шаравтар цагаан, *хулгана орд болгон хураах учир хулганын тос ч гэдэг.*

АТГАХ 1. юмыг гарын алганд базан барих; *жолоог гартаа атгав;* 2. гар зангидах; *гараа чанга атгалаа;* 3. ш и л ж с э н эрхэндээ оруулах.

АТГУУЛАХ 1. атгахын үйлдүүлэх хэв; 2. атгагдах.

АТИГА: атига атига хийх атигар юмны үргэлжлэн хөдлөх.

АТИГАНАХ атигар юмны атига атига хийх байдал.

АТИГАР хүн амьтны бие давжаа жижиг; **атигар нуруутай** (маш намхан биетэй).

АТИГАРДАХ хэтэрхий атигар болох.

АТИГАРХАН баахан атигар.

АТИЙЛГАХ атийхын үйлдүүлэх хэв; атийхад хүргүүлэх.

АТИЙХ жийх тэнийхийн эсрэг үг, гар хөл нугалхийлан агдайх, атирах; *хөлөө атийх.*

АТИЛЗАХ атигар юмны атис атис хийх.

АТИРАА 1. юманд гарсан нугалаа, хунираа, урчлээ; *эвхсэн хувцасны атираа гаргах; уулын атираа;* 2. нүүр биеийн урчгэр; *магнайн атираа;* 3. усны ар; *усны атираа.*

АТИРААТАЙ атираа бүхий юм.

АТИРАХ 1. урчийх, агдайх; 2. агийх; 3. эвхрэн цагираглан байх; *могой атиран хэвтэв.*

АТИРУУЛАХ атирахын үйлдүүлэх хэв; **хөмсөг атируулах** (хөмсгийн хоорондатираа гаргах).

АТИС: атис атис хийх атигар юмны байн байн хөдлөх.

АТЛАГА модон үйлдвэр хийхэд хэрэглэх багаж, оолийн адил болоод ховхи иртэй.

АТЛАГАДАХ атлагаар юмыг ухан цавчих.

АТЛАС I дэлхийн байдал, тэнгэрийн утга, амьтан ургамлын судлалын зэрэг ухаанд холбогдох зургийн дэвтэр; *газар зүйн атлас; ургамлын атлас.*

АТЛАС II нэг зүйл торгомсог эд.

АТЛЕТИК хүний биеийг хатуужил тэсвэртэй, эрүүл чийрэг, хөнгөн шаламгай чадалтай болгох биеийн тамирын янз бүрийн дасгал; **хүнд атлетик** (бокс, барилдаан, хүнд юм өргөх); **хөнгөн атлетик** (шидэх, харайх, гүйх, явган уралдах).

АТМОСФЕР хийн мандал, агаар; 1. дэлхийг бүрхсэн нүднээ үл үзэгдэх хийн мандал; 2. агаарын даралтын нэгж; *атмосферийн даралт.*

АТОМ тодорхой нэгэн язгуур махбодын шинж чанар бүхий бодисын хамгийн бага хэсэг; *атомын цахилгаан станц; атомын бөмбөг.*

АТРАХ авчрах, авч ирэх.

АТТАШЕ дипломат байгууллагуудад тусгай ажил хариуцсан бөгөөд тэр талаар зөвлөх үүрэгтэй албан тушаалын хүн; *худалдааны атташе; цэргийн атташе; соёлын атташе.*

АТТЕСТАТ ерөнхий боловсролын үнэмлэх.

АТУГАЙ юу болович; *ямар атугай ч үзсүгэй!.*

АТУУ эм загас.

АТУУХ эр загас.

АУГАА маш их, онц гарамгай, хүчин чадал төгс; *Октябрийн аугаа их нийгэм журамт хувьсгал.*

АХ 1. эцэг эхээс төрсөн хүүхдийн эрэгтэй бөгөөд түрүүлж гарсан; *миний ахын нэр Бат; ах чинь хэзээ ирэх вэ?; ах дүү нар;* 2. насаар ах; *надаас хоёр ах;* 3. найртай, ойр дотно; **ах дүү** х о р ш.; *ах дүүгийн найрамдал; ах дүүгийн барилдлага;* 4. насаар илүү учраас хүндэтгэвэл зохих; *хүн ахтай, дээл захтай* х.у у ч.; *ах зах хүн;* 5. зэрэг тушаалаар дээгүүр.

АХАЙ I 1. хөгшин настай эмэгтэй хүнийг хүндэтгэж ийнхүү дуудна; 2. урьдын цагт ноёны хатныг ингэж хүндэтгэн дуудаж байжээ.

АХАЙ II бага хүүхдийг урамшуулахад; ***ахай тэгээрэй хүү минь!.***

АХАР I 1. богино, охор, *ахар богино хугацаа;* 2. хонийг хяргасны дараа дахин ургасан ноос; *ахар авах;* ☆ **ахар сүүл** (хүн амьтны нурууны ясны шувтрах үзүүрийн бяцхан яснууд).

АХАР II аахар.

АХАРДАХ хэтэрхий ахар болох.

АХАРДУУЛАХ ахарлахын үйлдүүлэх хэв; ахар болох, богинодуулах.

АХАРЛАХ 1. зун хяргасан хонины ноосыг намар дахин хяргах; 2. арьс ширийн үсийг зүйлэхэд багаж зэвсгийн ир мохоо учир үс үлдээх.

АХАРХАН баахан ахар.

АХАРХАХ ах зан гаргах.

АХАРХУУ ах зан гаргамтгай.

АХАС I насны хувиар дээш үеийн хүмүүс; **ахас захас** х о р ш . .

АХАС II: **ахас ухасхийх** бусдыг хүндлэх мэтэд биеийг асар хөнгөмсөглөн хөдлөх.

АХАСЧИЛАХ ахыг хичээнгүйлэн хүндлэх.

АХДАХ хир хэмжээнээс хэтдэх; *энэ ажил надаас ахдаж байна.*

АХДУУ хирээс хэтрүү давуу.

АХДУУЛАХ ахдахын үйлдүүлэх хэв; ихдүүлэх; *давсы нь ахдуулчихлаа.*

АХИА а м ь т а н цулбуурттай адил бөгөөд бяцхан, шар алаг өнгөтэй, далбаа нуруундаа хагадастай нэг зүйл загас.

АХИАД I 1. насан бага биш бөгөөтөл бие нэн бяцхан; 2. нас бяцхан боловч ихжээр зан аальтай.

АХИАД II дахиад; *ахиад нэг харвал тэр мөн байжээ*

АХИГЛАХ аахилах, амьсгаадах, амьсгал сүйлэглэх.

АХИМАГ нас ахьсан, настай; *ахимаг настай хүн байв.*

АХИМАЛ хүн амьтны нас шүд ахисан нь

АХИМГАЙ ахимаг.

АХИМХАЙ улам амтшин даврах зантай; *ахимхай хүн арван гурав дахих* з үй р.

АХИР: ахир шихэр аахар шаахар.

АХИУ 1. ахимаг; *нас ахиу;* 2. нэмүү, их; *ахиу авахыг хичээх;* 3. дөхүү; **ахиу дөхүү** х о р ш.

АХИУЛАХ 1. ахихын үйлдүүлэх хэв; 2. дээшлүүлэх, урагшлуулах.

АХИУХАН баахан ахиу.

АХИХ I 1. нэмэгдэх, дээшлэх, дөхөмжлөх; *нас ахих; тушаал ахих; хийж байгаа ажил урагш ахиж өгөхгүй байна;* 2. ш и л ж с э н улам амтшин дабрах.

АХИХ II дахих.

АХИЦ ахих явцын нэр.

АХЛАГЧ тэргүүлэгч, толгойлогч; *ахлагч тогооч,* **галын ахлагч** (нэгэн гал болж аялан явагчдын толгойлогч); **төлөөлөгчдийн ахлагч** (төлөөлөгчдийн тэргүүн); **ахлагч дэслэгч** (цэргийн цол).

АХЛАХ 1 .ахчилан явах; 2. эрх тушаалын зэргээр тэргүүлэх; *ахлах дарга нар; ахлах дэслэгч; ахлах түрүүч.*

АХЛУУ ахдуу.

АХЛУУЛАХ 1 .ахлахын үйлдүүлэх хэв; 2. ахлагдах.

АХМАД 1. цэргийн даргын цол; 2. элдэв хөлөг онгоцны дарга; 3. биеийн тамирын багийн дарга; 4. аливаа нас ахлаач; **ахмад хийл** (хамгийн бүдүүн эгшиглэх чавхдаст нумт хөгжмийн зэвсэг, хэлбэр хийлийн адил болоод маш том, босоо зогсож хөгжимддөг, голдуу дөрвөн чавхдастай бий); **ахмад чавхдас** (чавхдаст хөгжмийн зэвсгийн хамгийн бүдүүн чавхдас).

АХУ бий, бүхий.

АХУЙ 1. бүхий; *намайг гэртээ ахуйд энэ мэт сонсогдов;* 2. байгаа; *ахуй байдал;* **ахуй нөхцөл, ахуй болзол** (ямар нэгэн үйл ажлыг гүйцэтгэх нөхцөл боломж); 3. аж гэдэгтэй холбон „аж ахуй" гэнэ; 4. асар; *ахуй их;* **ахуй их ятга** (хорин таван чавхдасанд тэвх тулж хуурдах нэг зүйл хөгжмийн зэвсэг).

АХУУ сансар, орчлон.

АХУУДЛАХ б и ч и г хүний гэм хоригийг уудлах, дургүйг хүргэх, цаашлуулах.

АХУУЛАХ б и ч и г хүн амьтныг удаан буюу түр хоргодоход хүрүүлэх; *хулгайг халгаан ахуулав; хүнийг халгаан ахуулахгүй үлдэн зайлуулав.*

АХУУНА а м ь т а н цэнгэг уст нуур цөөрөмд өндөглөдөг, загасан идэштэй, арьс нь үслэг ангийн эд таваарт орж ашиглагддаг нэг зүйл шувуу.

АХЧЛАХ нас илүү хүнийг ахын ёсоор хүндлэх; **ахчлах дүүчлэх** х о р ш..

АХЧЛУУЛАХ 1. ахчлахын үйлдүүлэх хэв; 2. ахчлагдах.

АЦ I 1. салаа; *ацтай мод; хошгиногийн ац; модны ац дээр шувуу суув; өвсний ац;* ☆ **ац туурайтан** (хоёр хэлтэс туурайт амьтад; *үхэр хонь бол ац туурайтан мөн);* **ац адаг** (мөрөн голын нуур далайд олон салаа салбар болон цутгах газар); 2. ш и л ж с э н **ац будлиан** (хоёр тийш сэжигтэй будлиан); **ац нийлэх** (хэргийг хоёр этгээдээс нийлэн шийтгэх); **ац хэл** (томьёолсон ёгт хэл); **ац хиаг** (салаатай хиаг).

АЦ II аль, өг; *над ац!.*

АЦ III өөш уях хэлтэй мод; *ац өөш.*

АЦАА гацаа, тээг; *надад ацаатай явдал тохиолдоод байна.*

АЦАГ I хүний бие, хөрөнгөөр ямар нэгэн ажилд хөдөлмөрлөсөн хүчний үнэд өгөх хөлс *ацаг авах;* **ацаг хөлс** х о р ш..

АЦАГ II монгол бичгийн шүд буюу өргөс; *ацаг шүдтэй бичих.*

АЦАГЛАХ өөрт оногдсон ажил явдлыг бусдад хөлс өгч төлөөлөн гүйцэтгүүлэх; *улсад тушаах сүүг ацаглав.*

АЦАТ ац бүхий юм; **ацат сум** (анга сумын адил болоод дотоод этгээд хавчуу, өмнөх нь цалгар, хойдох нь шувтан нэг зүйл сум).

АЦАХ арцах, хойргоших, маргах гацах.

АЦДАХ 1. ацаар өлгөж өргөх; 2. ацат зүйлээр тулах; хавчих; 3. заадас нийлүүлэх юмны нэгийг ац гаргаж нөгөөд үнхүүлэх; 4. ш и л ж с э н хоёр янз болох.

АЦЛАХ 1. юманд ац гаргах; 2. ацаар өргөх, өлгөх; 3. адуу таргалан хондлойн хоёр этгээд гудийн гарах; *ацалсан тарган морь;* 4. хамхаг шивээ зэрэг ургамлын үндэслэж цухуйх; 5. бичиг бичихэд нэгэн мөрт хоёр зэрэгцүүлэн салгаж бичих; 6. ш и л ж с э н үйл хэрэгт өөр учир шалтгаан гарч ирэх.

АЦЛУУЛАХ 1. ацлахын үйлдүүлэх хэв; 2. ацлагдах.

АЦРАХ авчрах, авч ирэх.

АЦРУУЛАХ 1. ацрахын үйлдүүлэх хэв; 2. ацрагдах.

АЧ I 1. эрхэм, тус; *ачтай тустай хүн; хайрт нам засгийн минь ач!; юуны ач вэ?; эхийн ач;* **ачийг бачаар** х у у ч. (тус хийсэн хүнд хор хүргэх); **ачийг хариулах** (ач тус болсны хариу тус хүргэх); 2. учир, нөлөө, тус; *уулын нөмөрт буусны ачаар цасанд дарагдсангүй; модны ойр буусны ачаар түлш тасарсангүй;* ач үр х о р ш.; *Октябрийн их хувьсгалын ач үрээр эрх чөлөөгөө олсон ард түмэн.*

АЧ II I. хөвгүүн буюу хүүхний хүүхэд; **ач хүү** (төрсөн ах дүүгийн хүүхэд); **үр ач** (а. үйл явдлын хариу боловсрох; б. хөвгүүд ач нар).

АЧ III: **ач тач**; ана мана, **ач тач** *(яг тэнцүүхэн, хэн хэнийгээ дийлэхээр биш; ана мана, ач тач ноцолдов).*

АЧАА 1. ачих тээх юм; *ачаа нь хүндэджээ; би ачаа ихтэй;* сүүлийн тэмээний ачаа хүнд з ү й р; *ачаа тээш; ачаа чүчээ;* 2. юм ачсан хөсөг; *манай ачаа ойртож явна;* **ачаа хөсөг** х о р ш.. ᠠᠴᠠᠭ ᠬᠥᠰᠦᠭ

АЧААГҮЙ тээшгүй, хөнгөн . ᠠᠴᠠᠭᠤᠢ ᠬᠥᠩᠭᠡᠨ

АЧААДАХ ачаа нь хүнддэн дааж ядах. ᠠᠴᠠᠭᠠᠳᠬᠤ

АЧААЛАХ ачаагаа ачих; *манайх нүүх гэж ачаалж байна;* **аавынхыг ачаалж өгөөд ирэв.** ᠠᠴᠠᠭᠯᠠᠬᠤ

АЧААЛУУЛАХ 1. ачаалахын үйлдүүлэх хэв; 2. ачаалагдах. ᠠᠴᠠᠭᠯᠠᠭᠤᠯᠬᠤ

АЧААР үр, тусаар; *сайн эмчийн ачаар өвчнөөс ангижрав; ардын засгийн ачаар сайхан амьдарч явна.* ᠠᠴᠠᠭᠠᠷ ᠪᠠᠭ

АЧИМГАЙ ачаанд сурсан. ᠠᠴᠢᠮᠭᠠᠢ

АЧИМХАЙ ачаа.ачуулж сурсан мал; *ачимхай үхэр..* ᠠᠴᠢᠮᠬᠠᠢ

АЧИТ ач тус бүхий; *ачит хүн; ачит эх; ачит төрийн аврал.* ᠠᠴᠢᠲᠤ

АЧИХ 1. юмыг морь мал, тэрэг чарга зэрэг дээр тохируулан тэгнэх, тавих; *галт тэргэнд нүүрс ачлаа; моринд ачаа ачих;* 2. ш и л ж с э н өөрийн ял зэмлэл зэргийг бусад хүнд түлхэн үүрүүлэх; *бурууг аа бусдад ачихыг оролджээ;* 3. барилдахад нөгөө этгээдийг хөл дээгүүрээ ургш давуулан тагаж унагах. ᠠᠴᠢᠬᠤ

АЧЛАГА ачаа ачих хөсөг мал; *ачлага олонтой айл;* **ачлага хөсөг, ачлага уналга** х о р ш.. ᠠᠴᠢᠯᠠᠭ

АЧЛАЛ ачтай тустай хүнд хариулал болгон ачлах үйлийн нэр; *үр хүүхэд нь эцэг эхдээ ачлал хүргэх нь зүй ёсны хэрэг.* ᠠᠴᠢᠯᠠᠯ

АЧЛАЛТ ачлал бүхий; 1. эцэг эхээ элбэрэх сайн хүн; *ачлалт охин; ачлалт бэр;* 2. олон түмний хэрэгт онц тус үзүүлсэн хүн; *ачлалт хүн.* ᠠᠴᠢᠯᠠᠯᠲᠤ

АЧЛАХ **ач** тусыг санаж хариу тус хийх; *ачийг хариулах.* ᠠᠴᠢᠯᠠᠬᠤ

АЧЛУУЛАХ 1. ачлахын үйлдүүлэх хэв; 2. ачлагдах. ᠠᠴᠢᠯᠠᠭᠤᠯᠬᠤ

АЧМАГ I аар саар юм хийх, морь малын нуруунд ачихад тохируулан хийсэн нэгэн зүйл сав; хэлбэр байдал богцтой адил болоод багахан; **ачмаг сэвэг** (бургас модоор сүлжиж хийсэн нэгэн зүйл сав; хэлбэр дүр авдар мэт). ᠠᠴᠢᠮᠠᠭ

АЧМАГ II ачимгай.

АЧУУ: **ачуу бачуу** яаруу давчуу. ᠠᠴᠤᠭ

АЧУУЛАХ 1 .ачихын үйлдүүлэх хэв; 2. ачигдах. ᠠᠴᠤᠭᠯᠠᠬᠤ

АШ тав тух. ᠠᠰᠠ

АШГҮЙ 1. хүсэж бодсон үйл явдал санаа бодолд тавтайяа нийлэлцсэнд гаргах аялга; *ашгүй чи ирэв үү!; ашгүй юун сайн юм бэ!; ашгүй морьтой болоо шив дээ!; ашгүй ямар сайхан завшаан тохиолдов!;* 2. тун сайн, санаанд тохиром, чанар сайтай; *ашгүй сайн хүү; ашгүй морь.* ᠠᠰᠠᠭᠤᠢ

АШИГ I 1. зарлагаас илүү гарч байгаа орлогын хувь; *арван мянган төгрөгийн цэвэр ашиг олжээ;* 2. өртөггүй орох, олз юм; *хувийн ашгийг харах; олз ашигт шунах;* 3. мал мэтээс гарах хэрэгцээт зүйлс; *малын ашиг шимийг дээшлүүлэх арга зам;* 4. тус дөхөм; *хот орсон нь ашиг болов;* **ашиг хонжоо; ашиг орлого; ашиг эрмэлзэлгээ; ашиг завшаан; үр ашиг; эрх ашиг** х о р ш. ᠠᠰᠢᠭ

АШИГ II биед гарах ур булуу.

АШИГГҮЙ 1. үр орлогогүй; 2. үл тохирох; 3. тусгүй. ᠠᠰᠢᠭᠤᠢ

АШИГЛАГДАХ ашиглахын үйлдэгдэх хэв. ᠠᠰᠢᠭᠯᠠᠭᠳᠠᠬᠤ

АШИГЛАЛ ашиглах үйлийн нэр. ᠠᠰᠢᠭᠯᠠᠯ

АШИГЛАЛТ ашиглах явц байдал; *техникийн ашиглалтыг сайжруулах.* ᠠᠰᠢᠭᠯᠠᠯᠲᠤ

АШИГЛАХ 1. ашиг болгох, өөрийн хувьдаа авч завших; *улсын хөрөнгийг ашигласан гэмт хэрэг;* 2. бусдын юмыг хэрэглэх; *хүний унааг ашиглах;* 3. албан газар буюу хүний нэрээр далимдуулах; *албан газрын нэрийг ашиг ласан зальт этгээд;* 4. хүний алдаа бурууг аар далимдуулах; *хүний сул талыг ашиглах;* 5. мөрдөж баримтлах; *цаг ашиглах.* ᠠᠰᠢᠭᠯᠠᠬᠤ

АШИГЛУУЛАХ 1. ашиглахын үйлдүүлэх хэв; 2. ашиглагдах. ᠠᠰᠢᠭᠯᠠᠭᠤᠯᠬᠤ

АШИГТ ашигтай, үр бүхий; **ашигт малтмал** (газрын хөрсөн дороос малтаж авах элдэв баялгийн зүйл). ᠠᠰᠢᠭᠲᠤ

АШИГТАЙ ашиг тус бүхий, олз орлоготой; *ард түмний амьдрал байдалтай танилцсан явдал надад ашигтай болов; цагаан идээ хэрэглэх явдал хүний биед маш ашигтай байдаг;* **ашигтай талбай** (ашиглагдах талбай). ᠠᠰᠢᠭᠲᠠᠢ

АШИД эдүгээ төдийхний биш үүрд гэх санаа; *ашдын хэрэг; ашдын тус; ашдын нохор;* **ашид бялзуухай а м ь т а н** (хаварч бялзуухай). ᠠᠰᠢᠳ

АШЛАХ амар тавиу сууж баахан удтал амсхийх, сэгхийх, тавлах; **ашлах тавлах** х о р ш..

АШТАЙ аятай, нийлэмжтэй, тохиромжтой гэсэн санаа; *аштай вэ дээ, аштай юу даа; хавар эрт үнээ тугаллавал аштай юу, сүүтэй цай ууна.*

АШТАЙХАН аятайхан; *энэ морь яасан аштайхан морь вэ!.*

АШУУВАНИ з у р х а й Шийдмийн ордын гурван одны нэр.

АЮУ I буюу, байхах сэжиглэх газарт гаргана; *ийм аюу; тийм аюу.*

АЮУ II бяцхан хэлтгий хэвгий газар; *аюу газар.*

АЮУЛ I гамшиг зовлон учруулж болох хор хөнөөлтэй юм; *дайны аюул; аюул эмээл; аюулаас гаталав; улсын аюулаас хамгаалах байгууллага.*

АЮУЛ II я р и а овоо дориун; *аюулын бузгай хүүхэд, бүтээгээд ирсэн байна, аюул л даа.*

АЮУЛ III з у р х а й Ангариг гаригийн хоёр дагуулын дотоод талын одны нэр.

АЮУЛАХ уулын ан амьтныг үргээн авлах.

АЮУЛГАХ аюухын үйлдүүлэх хэв; айлгах.

АЮУЛГҮЙ 1. аймаар жигшмээр юмгүй; *аюулгүй амьтан;* 2. айх болгоомжлохыг мэдэхгүй; *чи над аюулгүй халдана уу!;* 3. я р и а бузгай, овоо, сайн; **аюулгүй зантай** (нилээд сайн зантай).

АЮУЛТ аюул бүхий, хөнөөлтэй; *аюулт өвчин; аюулт салхи.*

АЮУЛТАЙ 1. эмээлтэй, айвал зохих; *аюултай шуурга болжээ; цахилгаан утсаар оролдох аюултай шүү ,мэдээрэй!*; 2. бэрх, хэцүү; *аюултай сэргэлэн; аюултай дүрсгүй.*

АЮУЛХАЙ өвчүүний хоёр урт сүврэг ясны хооронд аймхай мөгөөрсний тус газар; *аюулхай дээр бараагнах.*

АЮУМТГАЙ аймтгай.

АЮУМХАЙ аймхай.

АЮУМШИГ аймшиг.

АЮУМШИГГҮЙ аймшиггүй.

АЮУМШИГТАЙ аймшигтай.

АЮУХ айх.

АЮУХАН 1. баахан аюу; *аюухан газар;* 2. зөөлөн аяархан; *чи аюухан яваарай! .*

АЯ I 1. дуу хөгжмийн эгшиглэхэд дан эгшгүүдийн дэс даралдаа; 2. дуу хөгжмийн дан хөгөөр эгшиглэх байдал; 3. дуу; **ая барих** (а. найр дээр дуулах; б. тал засах); **ая нийлүүлэх** (дуу хөгжмийн хөг нийлүүлэх).

АЯ II 1. эв зүй *ая зүйг олох;* **ая ханьгүй** (бусадтай нийцэхгүй этгээд зантай); 2. арга, зам; **аяы нь олох** (нэг тийш нь болгох); 3. ааш, авир; *хүний аяыг дагах; аяар нь байлгах.*

АЯ III: **ая зан** *ажил үйл; ая зан юу хийж байна?*; **ая шалтаг** (далим дашрам).

АЯА хүний гайхах, сайшаах, гомдох, шүүрс алдах зэрэгт гаргах аялга; *аяа жигшмээр зүйл байна!; аяа хөөрхий!.*

АЯАР 1. нам, намжуу, чанга биш; *аяар дуугарах; аяар цохих;* 2. алгуур, удаан; *аяар явах; аяар аяар! битгий давхи!;* 3. я р и а дараа, жаахан ,хожим; *аяар би танайд очно.*

АЯАРДАХ хэтэрхий аяар болох; *радио аяардаад муу сонсдож байна.*

АЯАРЛАХ удаан аажим болох, болгох.

АЯАРТАХ улам аяар болох; *галт тэрэг аяартсаар яваад зогсов.*

АЯАРХАН 1. баахан аяар; *чихэнд нь аяархан хэлэв;* 2. барагтайхан, тааруухан, *ажлаар аяархан хүн.*

АЯГ зан ааш; **аяг ааш** х о р ш. ; *аяг нь олдохгүй хүн.*

АЯГА идэх уухад идээ ундаан хийж ам тулгаж хэрэглэх сав; *аяга шаазан; модон аяга; мөнгөн аяга; аяганы алчуур; аяганы гэр; аяганы үүт;* **аяганы хийц** (цай уухдаа аяганд хийх идэх идээний зүйл); *аяганы амсар зуух.*

АЯГА II: **аяга тахимлаг** шашны ёсны гэлэн сахилтан.

АЯГАЛАХ аяганд хийх; *хоол аягалав.*

АЯГАЧ урьдын цагт хаад ноёдод аягы нь барих гэрийн зарц.

АЯГГҮЙ ааш муутай. *аяггүй амьтан.*

АЯГЛАХ 1. элдэв ааш авир гаргах; 2. ааш-лах, загнах.

АЯГЛУУЛАХ 1. аяглахын үйлдүүлэх хэв; 2. аяглагдах.

АЯГҮЙ 1. нийлэмжгүй, эвгүй, тааламжгүй; *ирэхэд нь байхгүй бол аягүй юм болно; аягүй өдөр байна; бие аягүй байна;* 2. муухай, ширүүн; *аягүй зан гаргах.*

АЯГҮЙРХЭХ 1. муу ааш гаргах; 2. эгдүүцэх, жигших; 3. ш и л ж с э н байдал зохисгүйрэх; *тэнгэр аягүйрхэв.*

АЯГҮЙЦЭХ 1. уурлан ундуулах; 2. дургүйцэх.

АЯД хориглон зандахад хэрэглэх аялга; *дуу чимээгээ ялд!.*

АЯДАХ бүсдын аяыг дагах, бүсдын санаа зорилгыг дагах; **аядан дагалдах** (хүний үйл явдал, санаа зорилгыг гуйван дагаж өөрийн бат тогтворгүй байх; *аядан дагалджээ*).

АЯЖ хөгжмийн жижигхэн зохиол.

АЯЛАХ I 1. аян хийх, аялан явах; *алс газар зорьж аялан явахын цагт.*

АЯЛАХ II 1. бүсдын сэтгэл байдалд нийлүүлэхийн тул элдвээр аашлах, аргалах; 2. бялдуучлан аргадах.

АЯЛАХ III дуу эгшиглэх, аялгуулах; *дуу аялж суув;* ☆ **аялан унших** (ном уншихдаа ая оруудах).

АЯЛАХ IV бага сага авлах.

АЯЛГА I. сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлсэн утгатай үл хувилах үг; *(аялга үг; аяа, ай даа, хөөе, ээ дээ* гэх мэт); 2. харийн хэл буюу бусад нутгийн ярианы өвөрмөц дуудлагат эрхшээснээр өгүүлэх байдал; 3. ая аялгууны энгийн хэмнээн нэгж.

АЯЛГУУ 1. дуу хөгжмийн тус тусдаа биеэ дааж тодорхой яруу сонсогдохоор нэгэн зэрэг дуурсан эгшиглэх олон аяны цогцсын нэр; **аялгууны ухаан** (хөгжмийн давхар олон аяны зохирол найрал, хэлбэр шинжийг судлах ухаан); **аялгуут жүжиг** (зарим хэсэгтээ хөгжмийн хавсраа бүхий яриан жүжгийн нэг зүйл); 2. нэгэн хэлтний доторхи нутаг нутгийн хэл ярианы онцлог шинжит төрх; *аман аялгуу; салбар аялгуу;* 3. үг ярианы дуудлага.

АЯЛГУУЛАХ 1. дуу хөгжмийн ая аялгууг эгшиглэх зүйгээр өндөр богино, өтгөн шингэнд нийцүүлэн улируулж дуулах, хөгжимдөх; 2. олон хүний цугаар дуулалдах; 3. ном бичиг уянгалан дуудах.

АЯЛУУЛАХ I 1. юмны ая зүйг олж эмхлэх; цэгцлэх; 2. үйл ажлыг хийж дуусах, бараглах.

АЯЛУУЛАХ II аялахын үйлдүүлэх хэв; *танаар би нэг дуу аялуулъя.*

АЯЛУУН аятай, нийлэмжтэй.

АЯН I 1. алсыг зорьж хээрлэн явах явдал; **аян жин** х о р ш.; **аян хийх** (уналга хөсөг хэрэглэн алсыг зорьж аялах); **аяны хэрэглэл** (аянд явахад зохицуулан хийсэн хэрэглэл); ☆**аян дайн** (ямар нэгэн этгээдийг эсэргүүцэн байлдаан хийх; *загалмайтны аян дайн);* **аян шалтаг** (нэг зүйлээр шалтаг болгож өөр үйл хэргээс зайлах булталх завшаан олох).

АЯНГА оггоргуйн цахилгааны хорлол (дээр бүдүүлэг цагт аянга гэж галт сум мэт тусгай, маш их хүчтэй зүйл тэнгэрээс буудаг мэт буруу ойлгодог байжээ); **аянгын сум** (дээр бүдүүлэг цагт бороо орж цахилгаан цахилах үед тэнгэрээс буудаг хүрэл сум гэж буруу ойлгодог байв; «аянгын сум» гэж газраас олддог зүйл бол хүн төрөлхтний дээд үе хүрэл зэвсэгтэй байхад эдэлж байсан зүйлс болно); **аянга буух, аянга дайрах** (огторгуйн цахилгаанд дайрагдах); **аянга дуугарах** (тэнгэр дуугарах, аадар бороо хур орж, цахилгаан цахилахад нижигнэн дуугарах чимээ); **аянгын сарниул** (барилга төхөөрөмжийг аянга цахилгаан дайрахаас хамгаалах хэрэгсэл, голдуу утсаар газартай холбож босгосон урт төмөр байдаг).

АЯНГАЛАХ 1. аянга дуугарах; 2. аянга буух.

АЯНДАА өөрөө, зөндөө; *өөрөө аяндаа мэднэ; аяндаа бүтэхгүй явдал; тэр замаар явсаар байтал аяндаа хүрнэ.*

АЯНТАЛ ялдар, дашрам, *аянталаар явуулах; аянталын хүн.*

АЯНЧ аян хийхэд дадамгай сайн.

АЯНЧИН аян хийж яваа хүмүүс; *аянчны майхан.*

АЯНШИХ аян явдалд алжааж, өнгө царай муудах; *аяншиж ядарчээ.*

АЯС 1. хүн амьтны зан авир, төлөв байдал; 2. юмны учир чанарын тухай ээ зүй; *юмны аяс;* 3. дуу хөгжмийн ая аялгууны удаан түргэний төлөв; **аясаар бүтэх ажил** (үйлдсэн өгүүлсний ёсоор хялбархнаа болох бүтэх); **аяс хаалга** (ойрыг бодож чухам хаалганаас өөр газар хийсэн жижиг хаалга).

АЯСГАЛАН эелдэг нийлэмжтэй байдал.

АЯСДАХ дашрамд далимдуулан гүйцэтгэх, нааш эргэн хандах, таатай байдалтай байх.

АЯСЛАХ 1. бүсдын аясыг даган зөрөхгүй нийлүүлэн явах; 2. үйл явдлыг бүтээхээр үүсгэн завдах; 3. өвчний хөнгөрөх төлөвийг олох; 4. хүүхэд төрөхөд эхлэн дурсаж өвдөх.

АЯТАЙ санаанд нийлэмжтэй; *аятай зантай хүн; аятай байлгах.*

АЯТАЙХАН нилээд аятай.

АЯТАХ 1. үйл явдал бүтмээр болох; 2. өвчин хөнгөрөх төлөв мэдэгдэх.

Б

Б 1. Б үсэг, Б авиа; 2. хоёрдугаар, хоёрдахь гэсэн утгаар; *«Б»-д дурдсан нь; 10-ын «Б» анги;* **а б-гүй** (бичиг үсэг огт мэдэхгүй).

БА I бичгийн хэлний холбоос; өгүүлбэрийн доторхи тэгш эрхтэй гишүүдийг таслана; *мал ба хөдөө аж ахуй; марксизм ба ажилчин анги.*

БА II зөвхөн өгүүлэгчийг илтгэх биеийн төлөөний үгийн нэгдүгээр биеийн олон тооны хэлбэр; **ба бүрэн** (бид бүхэн, хамаг амьтан хүн тоотон).

БАА I хулс тэнз; *баа ташуур.*

БАА II торгууль зэмлэл; *найраас зөвшөөрөлгүй гарч одсоны баа.*

БАА III бааш, бач; *баатай хүн.*

БААВАА бага хүүхдийг ямар нэгэн зүйлээс жигшүүлэх; цээрлүүлэхэд хэрэглэх аялга; *ай баавааа!; муухай баавааа!.*

БААВАЙ ураг төрлийн хоорондох ахмад насны голдуу эрэгтэй хүмүүсийг хүндэтгэн ийнхүү дуудна.

БААВАР I эмээлийн хавтсан дахь ганзага ба худраганы сэжмийн **угт хадах чимэг;** *мөнгөн баавар.*

БААВАР II минж, халиуны зэхий муухан *арьс; баавар минж; баавар халиу.*

БААВГАЙ 1. **а м ь т а н** урт үстэй, бүдүүн хөлтэй, сүүн тэжээлтэн; махчин том амьтан; *цагаан баавгай; хүрэн баавгай; баавгайн цөс;* 2. давамгай; *тэр ч чамдаа баавгай.*

БААВГАЙЧЛАХ 1. баавгай агнахаар гөрөөчлөх; 2. **ш и л ж с э н** бусдыг өөрийн эрх-шээлээр давж дийлэх.

БААГИУЛАХ баагихын үйлдүүлэх хэв; баагихад хүргүүлэх; *утаа баагиулах; тамхи баагиулах.*

БААГИХ утааны багсран гарах; *яндангаас утаа баагиж байв.*

БААГУУР нэгэн зүйл идээ, исгэсэн шингэн гурилыг цоргоор гоожуулан жижиг бөөнөөр тасалж тосонд чанаж хийнэ.

БААЗ I жирийн, дунд зэргийн, муухан; *бааз морь.*

БААЗ II багц, боодол; *нэг бааз гоймон; нэг бааз шүдэнз.*

БААЗ III 1. найз; *тэр миний бааз мөн;* 2. аян жингийн хүмүүсийн гал нэгдэж явагчдын хөсгийн цуваа; **бааз хөөх** (ачаа хөсгийн хойно сэргийлэн явах хүн).

БААЗ IV 1. нийгэмлэгийн тухайн үеийн хөгжлийн эдийн засгийн баайгуулал; *социализмын материал техникийн бааз; коммунизмын материал техникийн бааз;* 2. нөөц; *тэжээлийн бат баазыг бий болгох;* 3. түр байрлаж байгаа түшиг газар; *мал тууврын бааз; цэргийн бааз;* 4. агуулах газар; *бараа бааз; түүхий эдийн бааз.*

БААЗЛАХ I юмыг сонгож, мууг заазлан гаргах.

БААЗЛАХ II юмыг хэсэг хэсгээр багц боодол болгох; *ачаа баазлах; гоймон баазлах.*

БААЗЛАХ III 1. хоёр хүн хоорондоо дотно найртай нөхөрлөх; 2. аян жингийн хүмүүс замдаа гал нэгтгэж хамтран явах.

БААЗХАН барагтайхан, муухан.

БААЛАХ I идээрлэх; *чихний цоорхой баалав.*

БААЛАХ II хөнгөн торгох зэмлэх; *найрын журам зөрчсөн учир гурван аяга айргаар баалав.*

БААЛУУЛАХ 1. баалах II-ын үйлдүүлэх хэв; 2. баалагдах; хөнгөн торгууль зэмлэлд өртөх.

БААРАГ осол омтгой хуумгай.

БААРАГГҮЙ осол омтгойгүй, лавтайяа; *бааргүй хүн; бааргүй арга.*

БААРАХ 1. сулрах, саарах, осолдох; **буу баарах** (авалцан дугарахгүй болох); 2. буцах, няцах; *хэлснээ баарах.*

БААРИН Өвөр Монголын нэгэн аймгийн нэр; *Баарин аймаг; Баарин хүн.*

БААРУУ 1. буцамгай, буцамхай, итгэшгүй; 2. сааруу хөөрүү; **баруу саруу; хөөрүү баруу х о р ш.**

БААРУУЛАХ 1. баарахын үйлдүүлэх хэв; 2. сааруулах, хойшлуулах.

БААС 1. **хүн амьтны өтгөн илүүдэл;** *ухрийн баас; шувууны баас;* **баас хаагдах** (баас хоригдох); **баас хатах** (а. баас хэтэрхий аглиурч хялбар гарахгүй **болох; б. хорон санаа агуу-**

лах; *баас хатавч өмхийгөө тавихгүй);* 2. хүдэр хайлах, нүүрс түлэх зэрэгт хаягдах хатуу хаягдал; *галын баас;* 3. билүүнд хутга билүүдэх зэрэгт гарах шавар мэт зүйл; *билүүний баас.*

БААСАН I долоо хоногийн тавдахь өдөр.

БААСАН II нарны аймгийн нэг ертөнц.

БААСГҮЙ ямар нэг ажил нь дутуу дулимгүй дахилтгүй хийдэг зангай; *тэр гуайн хийсэн ажилд баасгүй гэж итгэж болно.*

БААСДАХ юманд баас түрхэх; **хонь баасдах** (хонинд баасаар тэмдэг тавих);

БААСРАХ 1. баас болох, баас шиг болох; 2. зорьсондоо хүрэхгүй няцаж буцах; *чи баасрах хэрэггүй зоригло!.*

БААСРУУЛАХ 1. баасрахын үйлдүүлэх хэв; 2. бааруулах.

БААСТАЙ ямар нэгэн ажил нь хуумгай дутуу дулим болж заавал дахилттай хийдэг зантай; *түүний хийсэн ажил заавал баастай дахилттай байдаг юм.*

БААСТАХ баас тогтох; *хот бастчихжээ.*

БААТАЙ бач, бааш ихтэй, олон ааштай.

БААТАР 1. айж шантрахыг мэдэхгүй эрэлхэг зоригтой; 2. эрэлхэг зориг гарган гавьяа байгуулсан хүнд олгох цол; *хөдөлмөрийн баатар;* ☆ **баатар хуйх** (малын толгойн хоёр эврийн хоорондох хэсэг газрын арьс).

БААТАРЛАГ баатар зоригтой, эрэлхэг зоригтой; *баатарлаг үйл явдал; баатарлаг тэмцэв.*

БААТАРЛАХ сүрхий зориг зүтгэл гаргах.

БААТАРЛАХАХ баатар байдал гаргах.

БААТАРХАХ баатар сүр гаргах.

БААХ 1. баас гадагш гаргах; 2. юманд хүрсэн будаг зэргийн улам унгадан нүүх; *бэх баах.*

БААХАН нилээд, овоо, арай; *баахан их; баахан хол; баахан мал; баахан зогсож байгаад явлаа; баахан тусгүй явдал боллоо.*

БААЦАЙЛГАХ баацайхын үйлдүүлэх хэв; баацайхад хүргүүлэх.

БААЦАЙХ баацгар болох, баацгар юмны байгаа байдал.

БААЦАЛЗАХ баацгар юмны баацас баацас хөдлөх байдал.

БААЦАС: баацас баацас хийх; баацгар юмны байн байн хөдлөх.

БААЦГА: баацга баацга хийх; баацгар юмны үргэлжлэн хөдлөх.

БААЦГАНАХ баацгар юмны баацга баацга хөдлөх байдал.

БААЦГАР бага жижиг амьтны сая хөлд орж тэнцэж ядаж байгаа буюу тарган, жижиг биетэй амьтан; *баацгар гөлөг; баацгар хүүхэд.*

БААШ 1. илби; 2. арга бач; *бааш битгий гарга!.*

БААШГҮЙ гүндүүгүй, төлөв томоотой, заль мэхгүй.

БААШЛАХ бааш гаргах; *өвчтэй гэж бааширлжээ; нүд юм харахдаа муу гэж баашилсан ажээ.*

БААШЛУУЛАХ 1. баашлахын үйлдүүлэх хэв; 2. баашлагдах мэхлэгдэх.

БААШТАЙ бааш бач ихтэй, ааш авир ихтэй, **ааш бааш** хорш.

БАВАЙЛГАХ бавайхын үйлдүүлэх хэв; бавайхад хүргүүлэх.

БАВАЙХ 1. бавгар болох; 2. сахал ихэд ургаж бавгар болох; *бавайсан сахалтай.*

БАВАЛЗАХ бавгар юмны бавас бавас хийх.

БАВАС: бавас бавас хийх; бавгар юмны байн байн хөдлөх.

БАВГА: бавга бавга хийх; бавгар юмны үргэлжлэн хөдлөх.

БАВГАНАХ бавгар юмны бавга бавга хийх.

БАВГАР их сахалтай, үс ихтэй; *бавгар сахалтай хүн; бавгар үстэй малгай.*

БАВГАРХАН баахан бавгар.

БАВНАА дэмий ярихдаа дуртай.

БАВНАХ бавтнах.

БАВТНАА бавтнах зантай.

БАВТНАХ 1. ухна отолж ба ба гэж дуршин дуугарах; 2. шилжсэн дэмий ярих хэлэлцэх; *чи юу гэж бавтнаж байна; дэмий бавтнах хэрэггүй.*

БАВЧАА бавнаа бавтнаа.

БАВЧИХ хэтэрхий дэмий ярих.

БАВЧУУР бавчаа.

БАГ I орон нутгийн засаг захиргааны анхан

шатны байгууллага; *нэгдүгээр багийн ард.*

БАГ II өмсөх хиймэл толгой; **багт наадам** (толгойдоо баг өмсч наадах); **цамын баг** (цам гарахад өмсөх бурхад болон амьтны дүрсээр хийсэн хиймэл толгой); **багий нь хуу татах** (үнэн санааг илчлэн илрүүлэх).

БАГ III биеийн тамирын тэмцээний нэг тал болж нэгдсэн хэсэг; *баг нийлэх; сурын баг; шагайн баг.*

БАГ IV орчим; *арван цагийн багт уулзав.*

БАГА 1. хэмжээгээр их биш, жижиг, том биш; 2. бага настай; *залуу бага хүүхэд;* 3. эхний; доод шатны; **бага ангийн сурагчид** (нэгээс дөрөвдүгээр ангийн сурагчид); **бага сургууль** (анхан шатны сургууль); 4. доод түшаалын; **бага дарга** (доод түшаалын дарга); бага **дэслэгч; бага түрүүч** (цэргийн цол); бага **эмч** (дунд мэргэжлийн эмч); 5. тоо цөөхөн; **мал багатай айл** (мал цөөнтэй айл); **загас багатай гол** (загас цөөнтэй гол); ☆ **бага гарчиг** (номын ерөнхий гарчгийн дор бичих нэмэлт гарчиг); **бага сага** (аар саар, жижиг сажиг); **бага сагалах** (ажилтай ажилгүй хоёрын хооронд явах, юухан хээхнээр цаг өнгөрүүлэх); **бага тархи** (их тархийн доод этгээдэд байх жижиг тархи); **бага үд** (арван нэгэн цагийн орчим); **бага хүйтэн** (сарны зурхайн ёсны 24 улирлын нэг, ес эхлэхийн өмнөх арван таван хоног); **бага хэвэл** (хүний хүйснээс доош хэсгийн нэр); **бага авга** (эцгийн дүү); **бага авга бэргэн** (бага авгын эхнэр); **бага эвхмэл** (урьдын цагт айлтгах хэрэг зүйлийг бичиж сайдуудад үзүүлэн өргөх бичиг); **бага хураангуй** (утга зохиолын дотор өмнөд санааг хураангуйлан бичсэн үг); **бага хурал** (олон улсын болон албан байгууллагын төлөөлөгчдийн зөвлөлгөөн; *олон улсын эмэгтэйчүүдийн бага хурал; эрдэм шинжилгээний бага хурал);* **бага хаалга** (хаалганы самбарт болон хашаанд хийсэн жижиг хаалга); **бага хялгана** у р г а м а л (говьд ургадаг нэг зүйл хялгана).

БАГАВТАР арай бага, **их биш, цөөвтөр.**

БАГАГҮЙ ихээхэн, бага биш, арай том.

БАГАДАХ хэтэрхий бага болох, дутах; *ус багадаад үгааж болохгүй байна.*

БАГАДУУЛАХ багадахын үйлдүүлэх хэв; багадахад хүргүүлэх, дутаах.

БАГАЖ уран дархны **үйл** үйлдвэрт хэрэглэх зэвсэг; *мужааны багаж; дархны багаж; багаж хэрэгсэл; багаж зэвсэг; үйлдвэрлэлийн багаж зэвсэг.*

БАГАЖЖИХ багаж хэрэгсэл хангамжтай болох.

БАГАЖЛАХ багажгай болох.

БАГАЛЗУУР амны хөндийг улаан хоолойтой холбох суваг төвөнгийн орчин газар; **хоолой багалзуур** х о р ш.; **багалзуурыг шахах** (багалзуурын тус газраас атган цухалдуулах).

БАГАЛЗУУРДАХ 1. багалзуурын тус газраас зуух барих мэтээр ноцох; *чоно багалзуурдан ноцов;* 2. хоолойгоо шахаж муухай дуун гаран хашгирах.

БАГАЛЗУУРДУУЛАХ 1. багалзуурдахын үйлдүүлэх хэв; 2. багалзуурдагдах.

БАГАЛУУР у р г а м а л олон наст ургамал, төрөл зүйл олон; хавар намар өвлийн цагт тэмээнд сайн тэжээлтэй.

БАГАНА 1. юмыг тулах тулгуурдах хэрэглэл; *байшингийн багана; майхны багана;* 2. ш и л ж с э н бат түшиг тулгуур болсон; **төрийн багана** (утга зохиолд); ☆ **хамрын багана** (хамрын хоёр нүхний хоорондох тулгуур); **баганын ягаа** (баганын дээд үзүүрийн хээ хуар)

БАГАНАДАХ баганаар тулах, тулгуурдах.

БАГАНАДУУЛАХ баганадахын үйлдүүлэх хэв; баганадагдах.

БАГАНАЛАХ 1. баганадах; 2. баганаар цохих; 3. баганаар дарах.

БАГАНАТ багана бүхий юм; *баганат танхим;* **баганат жинлүүр** (хүнд юмыг өргөх хэрэглэл).

БАГАСАХ бага болох.

БАГАСГАХ бага болгох.

БАГАТАЙ муу, дутуу; бүтэмж багатай; *ажил багатай; чимээ багатай; ашиг багатай.*

БАГАТАХ улмаар бага болох.

БАГАТГАХ улам бага болгох.

БАГАХАН арай бага.

БАГАЧУУД бага насны хүүхэд, залуучууд.

БАГАЧУУЛ багачууд.

БАГАШИГ 1. арай бага, бяцхан дутуу; 2. залуухан.

БАГВААХАЙ I у р г а м а л шар өнгийн цэцэгтэй, ур нь үсэрхэг бөгөөд салхиар хялбархан тардаг нэг зүйл цэцэг.

БАГВААХАЙ II сарьсан баавгай.

БАГВАГАР бавгар, сахлаг, навтгар, пагдгар; *багвагар малгай; багвагар гэр.*

БАГВАЙЛГАХ багвайхын үйлдүүлэх хэв; багвагар болгох.

БАГВАЙХ багвагар болох.

БАГВАР нээлхийг ёроолд оруулан таглах таглаатай юм агуулах сав, бас хус гэж нэрлэдэг.

БАГИР хар дийлэнх өнгө; *багир хар; багир хүрэн.*

БАГИРАХ багир болох.

БАГИРДАХ хэтэрхий багирын учир тохиромжгүй болох.

БАГИРЛАХ багир болгох, юмны өнгийг хар дийлэнх болгох.

БАГИРТАХ улам багир болох.

БАГЛАА хэсэг хэсгээр багласан юм; *баглаа баглаагаар бараа овоолжээ.*

БАГЛАРАХ 1. багирах; *багларсан их ой; багларсан хар үүл;* 2. давчдах; *дотор багларах;* 3. бие хөшиж аягүй болох; *цээжин бие баглараад байна.*

БАГЛАХ I юмыг боож хүлэх бэхлэх; *ачаа баглах; бараа баглах;* **багласан бишгүүр** (нэгэн зүйл хөгжмийн зэвсэг, нарийн хар хулсан модыг урт богино зэрэгцүүлэн бүслүүрдэж үлээх ам тавин хийнэ).

БАГЛАХ II 1. юмыг баг баг болгон хуваах; 2. багт багтан орох.

БАГЛИУН 1. бүдүүн богино; 2. өтгөн, аглиун.

БАГЛУУЛАХ 1. баглахын үйлдүүлэх хэв; 2. баглагдах.

БАГС юманд юм түрхэх хэрэгсэл; *будгийн багс.*

БАГСАЙЛГАХ 1. багсайхын үйлдүүлэх хэв; 2. багсгар болгох.

БАГСАЙХ багсгар болох, сагсайх.

БАГСАХ баг багаар талцах.

БАГСГАР сагсгар; *багсайсан юм.*

БАГСДАХ багсаар түрхэх.

БАГСРАГА 1. хачир, хольц; 2. хольж хутгаж найруулсан нь.

БАГСРАГАЛАХ багсрага хийх.

БАГСРАХ юмыг хольж хутгаад нийцүүлэн найруулах; *гурил тос багсрах; будаг багсрах.*

БАГСРУУЛАХ багсрахын үйлдүүлэх хэв.

БАГТААЛГАХ багтаахын үйлдүүлэх хэв.

БАГТААМЖ эзлэгдэх зай талбай.

БАГТААМЖГҮЙ зай бага, багтац муутай.

БАГТААМЖТАЙ их зайтай, багтац сайтай; *хэдэн тонн ус багтах багтаамжтай сав вэ?*

БАГТААХ багтаахын үйлдүүлэх хэв; багтаахад хүрүүлэх.

БАГТАЛЦАХ 1. багтахын хамтран үйлдэлцэх хэв; 2. ямар нэгэн юмны дотор оролцон багтах; *танхим дүүрэн хүмүүс багталцан ядаж байв; би төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багталцаж явлаа.*

БАГТАМЖ эзлэх зай.

БАГТАМЖГҮЙ эзлэх зай ихгүй.

БАГТАМЖТАЙ эзлэх зай ихтэй.

БАГТАР ургамал өндөр нь хэд хэдэн алд, навч гүйлсний навчнаас бяцхан бөгөөд нимгэн, өнгө ногоовторхон, будахад хэрэглэж болдог, цэцэг шар, үр нь хэрээний нүд адил нэгэн зүйл мод.

БАГТАХ юмны дотор орох, оролцох; *хөндий дүүрэн мал багтаж ядан байв; санаанд багтах; гарт багтах; сарын дотор багтах; өршөөлд багтах; тоонд багтах; эрхэнд багтах.*

БАГТАХГҮЙ багтах боломжгүй, багтах аргагүй; *миний гутал багтдаггүй; аманд багтахгүй үг хэлэв.*

БАГТАЦ багтах зай; *багтац сайтай; багтац муутай.*

БАГТАЦГҮЙ багтаах зай тун бага буюу муу.

БАГТАЦТАЙ багтах зай ихтэй буюу сайн.

БАГТАШГҮЙ багтах аргагүй.

БАГТРАА дотор харанхуйлж, ухаан балартах нь.

БАГТРАХ ухаан балартаж дотор дүйрэх, санаа бодол давчдаж мэгдрэх.

БАГТРУУЛАХ багтрахын үйлдүүлэх хэв.

БАГЦ хэсэг хэсэг бааз болгосон юм; *багц гоймон; нэг багц шүдэнз.*

БАГЦАА тойм, бүдүүвч, барагцаа; *энэ номын багцаа арваад хэвлэлийн хуудас юм.*

БАГЦААЛАХ тоймлох ,бүдүүвчлэх, барагцах.

БАГЦАХ I барагцах, багцаалах.

БАГЦАХ II баг багаар таслах, талсах.

БАГЦЛАХ багц болгох.

БАГЦЛУУЛАХ багцлахын үйлдүүлэх хэв.

БАГШ эрдэм сургах хүн; *багa сургуулийн багш; гавьяат багш; багшийн сургууль; багшийн дээд сургууль.*

БАГШИМ 1. амьтны олон үлэмжийн байдал, нугт чигжүү; 2. өтгөн, аглиун.

БАГШИХ 1. амьтны олон үлэмж хуран цуглах; *багшсан олон хумуус үймэлдэж байна;* 2. өтгөрч багшрах; *чанасан будаа багшчихжээ.*

БАГШЛАХ багш болж заах.

БАГШЛУУЛАХ 1. багшлахын үйлдүүлэх хэв; 2. багшлагдах.

БАГШРАХ амьтны маш олноор хуран үймэх.

БАГШРУУЛАХ багшрахын үйлдүүлэх хэв.

БАД I нэгэн зүйл хээ зураг; *бад хээтэй торго; бадтай цөгц.*

БАД: бад мод у р г а м а л Энэтхэг оронд ургадаг бөгөөд нэг үндэснээс мөчирлөн гарч, мөчрүүд нь бүдүүрэн бүдүүрсээр биеэ даахгүй болж газар хүрээд дахин үндэслэн, тэндээсээ дахин мөчирлөн, мөчир нь дахин үндэслэх зэргээр нүүж ургах том мод.

БАД III: бад хар хав хар, гүн хар.

БАДАА бадан.

БАДААН бадаа, бадан.

БАДААС нэгэн зүйл идээ; хайлсан чихрийн усыг буцалган ширгээж хөөсөрсөн чихрийн хувийг юман дээр асгаж царцаан хийдэг.

БАДАГ I 1 .шүлгийн доторхи нэг мөр буюу нэг утгатай хэсэг; 2. шинэ мөр догол мөр; 3. дууны нэг түрлэг.

БАДАГ II: бадаг бүдэг бараг бүрэг, тодорхой биш, гэрэл гэгээ муутай; *бадаг будэг санагдана; харанхуйд бадаг будэг харагдана.*

БАДАГЛАХ шүлэг зохиолыг бадгаар хуваах.

БАДАЙРАХ I. хөөнгөтөж хавдах; *буйл бадайрах; нүүр бадайрах;* 2 .бие махбод шимшрэн халуу оргисон мэт болох; *бие бадайрах; гар хөөж бадайрах.*

БАДАН I х у у ч и р с а н багтаамжийн хэмжээ, арван их дүү хэмжээтэй юм.

БАДАН II 1. юмны урд унжуулах торгомсгоор алаглан хийсэн нарийн урт тууз мэт чимэг; 2. хүндэтгэх хүний өмнүүр өлгөх торгомсгоор хийсэн хөшиг.

БАДАН III у р г а м а л монгол цайнд ордог нэг зүйл өвс.

БАДАН IV: **бадан хар** бад хар.

БАДАР I: **бадар цэцэг** у р г а м а л салхины чийгрэм цэцэгтэй адил, өнгө шар нэгэн зүйл цэцэг.

БАДАР II: **бадар хээ** бадар цэцэгтэй төстэй нэгэн зүйл хээ зураг.

БАДАР III 1. **бадар аяга** тойдын тусал гуйх нэг зүйл аяга; 2. бусдаас эд юм хүсч гуйхы нь; *бадар барих.*

БАДАРЛАХ бадар барих, гуйх.

БАДАРЧ бадар гуйгч хүн.

БАДАРЧИН бадарч; **бадарчны үлгэр** (хошин шог үлгэрийн нэгэн зүйл).

БАДАРЧЛАХ бадар гуйж хэсүүчлэх, хэрэн явах.

БАДГАНА хүний ходоодонд тусдаг хорт халдварт өмөн өвчин, нарийн ч гэдэг.

БАДГАНАТАХ бадгана өвчин хүртэх.

БАДЛАХ бад гарах, бад хээ гаргах.

БАДЛИУН бүдүүн боргил; *бадлиун сайхан биетэй морь.*

БАДМА нэгэн зүйлийн хээ зураг; **бадма лянхуа** у р г а м а л (балчиг шаварт усанд ургадаг маш гоёмсог сайхан цэцэг; *цагаан бадма лянхуа; ягаан бадма лянхуа);* **бадма хорхой** а м ь т а н (амьтны цус сорон амьдардаг нэг зүйл хорхой; цэнгэг усанд байдаг түүнийг эмнэлэгт хүний цус соруулахад хэрэглэнэ).

БАДМАЛАХ бадма гарах, бадма хээ гаргах.

БАДМАРАХ бадма болох; *зул бадмарах.*

БАДМАРАГА чанар хатуу, өнгө улаан, гэрэлд улаан туяа цацрах нэг зүйл эрдэнийн чулуу.

БАДМАТАХ юманд бадма тогтох.

БАДНАХ дэмий чалчин ярих.

БАДРАА у р г а м а л уул хаданд ургана; навч хэв, цэцэг цагаан, намар цэцэглэдэг нэгэн зүйл цэцэг.

БАДРААХ бадрахын үйлдүүлэх хэв; **бадруулах.**

БАДРАЛ 1. хөгжил мандал, дэлгэрэл; 2. юмны эхлэл үүсгэл; ☆ **бадралт баг бишгүүр** (нэг зүйл хөгжмийн зэвсэг).

БАДРАНГУЙ бадран дэлгэрч, хөгжиж дээшилж яваа; *бадрангуй хөгжил; бадрангуй зориг;* **бадрангуй цэцэг** у р г а м а л (тэргүүлэгч цэцэгтэй адил бөгөөд өнгө шар, нэг цоморлигоос дөрөв таван хүйс цэцэглэнэ).

БАДРАХ улмаар хөгжих дэлгэрэх мандах.

БАДРИУ биерхэг, бүдүүн, байргашуу.

БАДРИУДАХ хэтэрхий бадриун болох.

БАДРИУН бадриу, бүдүүн, том, өсгөлөн.

БАДРУУЛАГЧ хөгжүүлэгч, дэлгэрүүлэгч, мандуулагч.

БАДРУУЛАХ бадрахын үйлдүүлэх хэв.

БАДТАХ юманд бад тогтох.

БАДЧАА эрээ цээргүй яримтгай.

БАДЧИХ эрээгүй зоригоор ярих.

БАЖГАДАХ сандрах, тэвдэх, бачимдах; *шалгалт өгөх гэж бажгадав.*

БАЖГАДУУ сандруу, тэвдүү, бачимдуу; бажгадуу хүн.

БАЖГАДУУЛАХ бажгадахын үйлдүүлэх хэв.

БАЖГИР ажгир, аржгар; *бажгир торго; бажгир дурдан.*

БАЖИЙ нэгэн зүйл тоглоом; тусгай хөлгөн дээр явуу орхиж наадна.

БАЖИЙДАХ бажийгаар наадах.

БАЖУУНА у р г а м а л гишүүнэ, гишүүний үндэс.

БАЗ I эгч дүү хоёрын хоёр эр хоорондоо харилцан баз болно.

БАЗ II бааз IV.

БАЗААХ үйл ажилд хэрэглэгдэх зүйлийг урьдаас зэхэж бэлтгэх; *сааль базаахаар сав базаа* ц э ц э н үг.

БАЗААХГҮЙ сайнгүй, аятай олигтой биш; *базаахгүй ястай эд; базаахгүй зантай хүн.*

БАЗАХ хүн амьтан гар савраар юмыг атгаж барих, мөн атгасан юмаа гарын салаагаар гаргах; *няц базах; аарц базах.*

БАЗЛАХ 1. байн байн базах; 2. гэдэс дотор базах мэт аягүй болох; *гэдэс базлах.*

БАЗЛУУЛАХ 1. базахын үйлдүүлэх хэв; 2. базлагдах, нухлуулах.

БАЗМАЛ базсан юм; **базмал ааруул** (аарцыг базаж хатаасан идээ).

БАЙ I 1. харваж буудахаар босгосон шав; *бай буудах;* 2. газрын хол ойрын хоорондын зай; *бай хол.*

БАЙ II мөрий, шан; *бөхийн бай; морины бай; бай олгох.*

БАЙ III байг, боль; *тоглохоо бай; ууж согтуурахаа бай;* ☆ **бай авах** (а. шан авах, мөрий авах; б. шаардан явж газар замын ихийг эзлэх; в. цох авах, цохдох).

БАЙВАН хүхэр хүчлийн давсан талст; *хар байван; цагаан байван.*

БАЙВАНДАХ юмыг байвантай усанд буцалгаж өнгө оруулах.

БАЙГ 1. боль, зогс, тат; 2. байх орхихыг зөвшөөрсөн; *байвал байж л байг; суувал сууж байг.*

БАЙГАА буй, бүх; *байгаа л тэмээгээ ачаалав.*

БАЙГАЛЬ байгаа бүх сав, шим ертөнц; *байгаль дэлхий; байгаль бодис;* **байгалийн ухаан** (сав, шим ертөнцийн тухай ухааны цогц; *байгалийн ухааны анги).*

БАЙГУА гаймуу ногооны үндэс.

БАЙГУУЛАГДАХ байгуулахын үйлдэгдэх хэв.

БАЙГУУЛАГЧ 1 .зохиогч, үүсгэгч, бий болгогч; *засаг төрийг үндэслэн байгуулагч;* 2. эрхлэгч, удирдагч; **сангийн аж ахуйн намын зохион байгуулагч** (сангийн аж ахуйд намын ажлыг эрхлэсэн хүн).

БАЙГУУЛАЛ 1 .улсын болон олон нийтийн байгууллага; *захирах байгуулал;* 2. нийгэм төрийн байгуулалт; *нийгэм журамт байгуулал; зөвлөлт төрийн байгуулал;* 3. ямар нэг юмны харилцан холбоо бүхий тогтолцоо; *хэл зүйн байгуулал.*

БАЙГУУЛАЛТ ямар нэг байгуулсан юмны явц; *зохион байгуулалт; нийгэм журамт байгуулалт.*

БАЙГУУЛАЛТГҮЙ ямар нэг байгуулсан юмны явц муутай, явцгүй; *зохион байгуулалтгүй; зохион байгуулалтгүй ажил.*

БАЙГУУЛАЛТТАЙ ямар нэг байгуулсан юмны явц сайтай, явцтай; *зохион байгуулалттай; зохион байгуулалттай арга явуулга.*

БАЙГУУЛАМЖ ямар нэг зохион байгуулсан юмны явцын шинж төрх; *улсын байгууламж.*

БАЙГУУЛАХ 1. үүсгэх, бий болгох; *засаг төр байгуулах; ардын хувьсгалт намыг үүсгэн байгуулах;* 2. цогцлон бүтээх; *бид нийгэм журмыг байгуулна; залуучуудын орд байгуулах;* 3. тогтоох; *гэрээ байгуулах.*

БАЙГУУЛЛАГА албан газар; *албан байгууллага; захиргааны байгууллага; олон улсын байгууллага; намын байгууллага.*

БАЙДАЛ аливаа юмны янз дүр төлөв, **янз байдал, дүр байдал, төлөв байдал, байдал төлөв, байр байдал, шинж байдал** х о р ш.; *цаг уурын байдал; биеийн байдал.*

БАЙДАС 1. сувай гүү; 2. шүдлэн хязаалан насны гүү; *байдсан гүү.*

БАЙДАСРАХ гүү, мэгжийн сувайрах.

БАЙЗ азна, хүлгэлз, дараа бол; *байз, би ажилтай байна!, хүлээж бай!; байз л даа!.*

БАЙЗНА баахан түдгэлз, азна; *одоо цаг болоогүй байна, жаахан байзна.*

БАЙЗНАХ азнах, хүлгэлзэх, түдгэлзэх; *та жаахан байзнахгүй юу?.*

БАЙЛАН хуучин муусайн цаасаар дахин боловсруулан хийсэн бүдүүлэг цаас.

БАЙЛАХ эд юмыг биечлэн тоолж шалгах байцаах; *эд хогшил байлах.*

БАЙЛГАХ 1. байхад хүрүүлэх; байхыг зөвшөөрөх, үлдээх, тогтоох; *эзэнтэй байлгах; дулаан байлгах; гэрэлтэй байлгах; хэвээр байлгах; бэлэн байлгах; өрөм байлгах; амар байлгах;* 2. болиулах; *тушаалаас байлгах; ажлаас байлгах; сургуулиас байлгах;* 3. занчих, цохих; *наадахаа байлгаад ав!.*

БАЙЛДААН бага хэмжээний газар хамарсан зэвсэгт тулалдаан; **дайн байлдаан** х о р ш. *байлдааны олз; байлдааны бэлтгэл; байлдааны газар.*

БАЙЛДААНЧ байлдаанд дуртай, чадамгай.

БАЙЛДАГЧ жагсаалын цэргийн албан хаагч.

БАЙЛДАХ дайтах, байлдаан хийх; *байлдан дагуулагч; байлдан дагуулах; байлдан эзлэгч; байлдан эзлэх.*

БАЙЛДУУЛАХ 1. байлдахын үйлдүүлэх хэв; 2. байлдагдах.

БАЙЛЦАХ 1. байхын үйлдэлцэх хэв; 2. байж оролцох, хамт байх.

БАЙЛЦУУЛАХ байлцахын үйлдүүлэх хэв.

БАЙМБАГАЙ 1. баймгай; 2. аажимдаа бодож байгаад; *баймбагайдаа байж байгаад болъё.*

БАЙМГАЙ нас бие гүйцсэн, байргашсан; *баймгай шар.*

БАЙН: байн байн дахин дахин, ахин дахин; *байн байн битгий ир!; байн байн асуух хэрэг алга.*

БАЙНГА үргэлж ямагт, дандаа; *байнга орших; байнгын ажилтай хүн.*

БАЙНГАРАХ адуу малын эдлэгээнд дордож түгших.

БАЙР I 1. орогнон орших газар, орон сууц, суурь, байгаа газартаа; *байр байрандаа суу! байраа эзэл!; оюутны байр.*

БАЙР II байц, байдал; **байр байц; байр байдал** х о р ш . .

БАЙРАН суурин, байнга, үргэлж; *хотод байран суугч.*

БАЙРГА I баймгай, төлөв томоотой.

БАЙРГА II адуунд тохиолдох нэгэн зүйл өвчин.

БАЙРГАТАХ байрга өвчин хүрэх.

БАЙРГАШИХ нас бие гүйцэх, байр суурь суух, төлөв байдал олох.

БАЙРГАШУУ байр төлөв олсон.

БАЙРГҮЙ 1. ул суурь муутай, тогтворгүй; 2. орон сууцгүй.

БАЙРЛАХ 1. байранд орж орших; 2. суурь төлөвийг олох; 3. хөнгөмсөг биш байдал гаргах.

БАЙРЛУУЛАХ байрлахын үйлдүүлэх хэв.

БАЙРШИХ 1. байран суух; 2. байр сууриндаа идээших.

БАЙРШУУЛАХ I байршихын үйлдүүлэх хэв.

БАЙРШУУЛАХ II байрлуулах.

БАЙСХИЙХ 1. байзнах; *байсхийж байгаад явъя;* 2. байн байн, дахин дахин болох; *байсхийгээд ирэх хэрэг юун?.*

БАЙТАЛ атал; *намайг явж байтал; чи хийх үүрэгтэй байтал яагаад эс хийв?.*

БАЙТАХ сур харвахад ногдсон сур уг хэмжээнээс үл гарах; *сур байтах.*

БАЙТЛААР сул, зүгээр, үнэ хямд; *буcдын юмыг байтлаар авч болохгүй.*

БАЙТУГАЙ атугай; *мориор байтугай явгаар ч гарч болохгүй бэрх газар.*

БАЙТУУ юманд дэвсгэр болгож түрхэх нэгэн зүйл цагаан будаг.

БАЙТУУДАХ будах юманд байтуугаар дэвсгэр болгож будах.

БАЙХ 1. орших, тогтнох; *одоо би хотод байх болно; хавар болтол хөдөө байх болно;* 2. үйлийн нэр, нөхцөл үйлийн зарим хэлбэртэй хамтран орж, тухайн үйлийн цагийг заана; *ажлаа хийгээд байх уу?; бид нар номоо үзсэн байх уу?; маргааш миний аав ирэх байх; шуудан одоо ирж байгаа байх; хэвтэж байх; явж байх; сууж байх хэрэгтэй;* ☆ **байх л юм чинь** (хааяагүй байгаа); **байх аргагүй** (тэсэх аргагүй); **байж болшгүй** (тэсч болшгүй); **байж ядах** (тэсч ядах); 3. болих, зогсох, тэвчих; *замбараагүй ажил хийхээ байх цаг болжээ!; чи явахаа байх л үгүй юу; байхаас биш дээ; одоо би гадуур зугаалахаа байх гэж байна.*

БАЙХГҮЙ үгүй, эзгүй алга; *таны сураглаcан хүн байхгүй байна.*

БАЙХУУ дулаан газар ургадаг үсэрхэг цагаан үртэй, хүрэн навчтай нэг зүйл цайны ургамал; *байхуу цай.*

БАЙЦ I байр байдал, шинж төлөв.

БАЙЦ II хавцал бэрх газар.

БАЙЦАА байцай.

БАЙЦААГДАХ байцаахын үйлдэгдэх хэв;

БАЙЦААГЧ 1. аливаа гэмт хэрэгтнийг байцах үүрэгтэй албан тушаалын хүн; *хотын прокурорын байцаагч;* 2. аливаа этгээдийн ажлын байдлыг хянан зааварлаж шалгах үүрэг бүхий албан тушаалын хүн; *сургуулийн хэлтсийн байцаагч; боловсон хүчний байцаагч.*

БАЙЦААЛ баримт, тодорхойлолт; *байцаал болгох; биеийн байцаал.*

БАЙЦААЛГА байцаах, хянах, шалгах үйлийн нэр.

БАЙЦААЛГАХ 1. байцаахын үйлдүүлэх хэв; 2. байцаагдах.

БАЙЦААЛТ байцаах явц; *мөрдөн байцаалт явуулж байна.*

БАЙЦААХ 1. ямар нэг зүйлийг илрүүлэхийн тул өчиг мэдүүлэг гаргуулахаар нягтлан асуух; *хэрэгтнийг байцаах;* 2. хянах шалгах; *данс байцаах; байцаах тэмдэггүй;* ☆ **байцаах тэмдэг** (хожим гэрч баримт болох юм): **байцаах тэмдэггүй болох** (ямар ч эмх замбараагүй болох).

БАЙЦАГДАХ байцахын үйлдэгдэх хэв.

БАЙЦАЙ идэшний ногоо; *орос байцай; хятад байцай; цэцэгт байцай;* ☆ **байцайны эрвээхэй** (цагаан эрвээхэйн нам, жигүүр цагаан, хар бидэртэй, байцайнд шар саг орхивол шаравтар ногоон хорхой гарч байцайг хөнөөнө).

БАЙЦАХ байцаах хянах, шалгах.

БАЙЦЛАГА байцах үйлийн нэр.

БАЙШИН хүн суух, юм агуулах мод туйпуу, чулуу шавар зэргээр барьсан барилга; *туйпуун байшин; гурван давхар байшин.*

БАКТЕРИ ян.

БАКТЕРИОЛОГИ ян судлал.

БАКТЕРИОЛОГИЧ ян судлагч.

БАЛ I зөгийн цэцгийн шүүсээр боловсруулах чихэр амттай өтгөн зүйл; *зөгийн бал; цагаан бал; шар бал.*

БАЛ II 1. нүүрс төрөгчийн нэгэн янзын эрдэс; харандаа, гал даах сав зэргийг хийнэ; *бал чулуу;* 2. харандааны гол.

БАЛ III 1. тугалга, зэс мэтийн төмөрлөгийг юманд хавирах үрэхэд гарах будаг; *тугалганы бал; зэсийн бал;* 2. зэс, төмөр мэтээс юманд орж шингэх амт; *зэсийн бал орсон сүү; бал амтагдах.*

БАЛ IV: **бал балбалах** хүүхдийн анх хөлд орох үед арай ядаж тогтнон зогсох.

БАЛ V 1. согтож буюу зөнөглөж ухаан мэдрэл алдрах, самуурах; бал болох; 2. балаг болох; **хар бал хорш.**

БАЛ VI эмийг ургамал, балуу.

БАЛАГ уршиг, харгаа; *чиний балгаар бид хожимдов; балгаа тарих; балаг болох; бадарч явсан газар балагтай, батгана суусан газар өттэй хуучч.*

БАЛАГЛАХ балаг болох.

БАЛАГТАЙ уршигтай, гайтай, хөөтэй; *балагтай хүн.*

БАЛАГТАХ бусдын балгийг өөрт хүртэх.

БАЛАГТУУЛАХ балагтахын үйлдүүлэх хэв;

БАЛАЙ I 1. сохор; **нүдэн балай, чихэн дүлий** з ү й р (сохроор, таавраар); 2. бүдүүлэг, харанхуй, мунхаг; *балай мунхаг; дэмий балай ярих;* 3. ухаан солиу; **элий балай** (ухаан солиу, ухаан солиурсан; *дотор элий балай болов*).

БАЛАЙРАХ 1. ухаан мэдрэл элий балай болох; 2. дэмий юм ярих.

БАЛАЙРУУЛАХ балайрахын үйлдүүлэх хэв.

БАЛАЙТАХ балай тэнэг байдал гаргах.

БАЛАНС орлого зарлагын талаар албан газраас тогтмол хугацаанд гаргах мэдээ; *худалдааны баланс; баланс нийлүүлэх;* **балансаар шилжүүлэх** (үндсэн хөрөнгийг тоо ёсоор нэг албан байгууллагаас нөгөө албан байгууллагад үнэ төлбөргүй шилжүүлэх).

БАЛАНСЛАХ 1. ямар нэг юмны хоорондоо тэнцэж тохирох; 2. баланс, тоо бүртгэл, тайлангийн нийт дүн харилцан яв цав тохирох.

БАЛАНСЛУУЛАХ баланслахын үйлдүүлэх хэв.

БАЛАНЧ уулгамч.

БАЛАНЧЛАХ уулга алдах.

БАЛАР 1. аливаа юмны тодорхойгүй, бүдэг; **балар будлиан** (хэрэг явдлын учир нь үл мэдэгдэх): **балар харанхуй** (хав харанхуй); 2. шигүү битүү; *балар ой; балар шугуй;* 3. эрт урьдын; **балар эрт** (судар түүхэнд тэмдэглэгдээгүй маш эртний үе; *балар эртний үеийн амьтан адгуус*); 4. ш и л ж с э н бүдүүлэг, учир утга нь мэдэгдэхгүй.

БАЛАРДАА балардах явдал.

БАЛАРДАХ 1. хэтэрхий балар болох; 2. ухаан мэдрэл бал бүл болох; 3. бахардах, мэгдүүрэх.

БАЛАРДУУЛАХ балардахын үйлдүүлэх хэв.

БАЛАРТАХ балар болох; *дотор балартах.*

БАЛАРТУУЛАХ балартахын үйлдүүлэх хэв;

БАЛАРХАЙ тодорхойгүй, мэдэгдэхгүй; *балархай бичиг; балархай зам.*

БАЛБА хэмх, бут, **балба цохих** (хэмх цохих)

БАЛБАА үргэлж эдлэгдэх юм; *балбаа дээл; балбаа унаа.*

БАЛБАГА: балбага балбага хийх балбагар юмны үргэлжлэн хөдлөх.

БАЛБАГАНАХ балбагар юмны балбага балбага хийх.

БАЛБАГАР 1. балтгар навхгар; 2. навсгар нэвсгэр.

БАЛБАЛАХ I 1. байн байн буюу зэрэг зэрэг балбах; 2. хэмхэлж эвдчих.

БАЛБАЛАХ II х у у ч и р с а н бага хүүхдийг алган дээр зогсоон наадах.

БАЛБАЛЗАХ 1. балбагар юмны балбас балбас хөдлөх; 2. дэнслэн донслон хөдлөх; *салхинд гэр балбалзаж байв;* 3. улдсан мал бэлбэгнэн арай ядан явах.

БАЛБАЛЗУУЛАХ балбалзахын үйлдүүлэх хэв.

БАЛБАРАХ хэмхрэх, няцрах, хагарах, урагдах; *хувцас балбарах.*

БАЛБАРХАЙ балбарсан юмны харагдах байдал.

БАЛБАС: балбас балбас хийх балбагар юмны байн байн хөдлөх.

БАЛБАХ 1. байн байн цохих нүдэх; *төмөр балбах; сүхээр балбалаа;* 2. ш и л ж с э н хувцсыг хайрлахгүй үртэлжлэн өмсөх; *дээлээ бал баж өмсөх.*

БАЛБАЧИХ балбалах, хэмхлэх, эвдчих.

БАЛБУУЛАХ 1. балбахын үйлдүүлэх хэв; 2. балбагдах, цохигдох; *мөндөрт балбуулав.*

БАЛГА 1. шингэн юмны аманд дүүрэхүйц хэмжээ; *нэг балга цай;* 2. ш и л ж с э н өчүүхэн, жаахан; *балга ус; балга архи.*

БАЛГАД 1. олон балгасан; 2. х у у ч и р с а н албан хэрэг шийтгэх газар.

БАЛГАДАХ 1. дэндүү элбэгжүү загнах; 2. сандрах тэвдэх.

БАЛГАДУУЛАХ балгадахын үйлдүүлэх хэв.

БАЛГАЛЗАХ балгадах.

БАЛГАЛЗУУР балгадах зангай.

БАЛГАМТГАЙ балгах дуртай; *архи балгамтгай.*

БАЛГАМХАЙ балгамтгай.

БАЛГАНА у р г а м а л өндөр нь хоёр метр орчим; хальс улаан, зөөлөн унгарал голтой, эмийн зүйлд хэрэглэдэг нэг зүйл мод.

БАЛГАС 1. эртний хот; **хот балгас** х о р ш.; **гандирсан балгас** (балгас мэт үзэгдэх зэрэглээ); 2. эвдэрхий хот, хотын суурь үлдэгдэл.

БАЛГАХ шингэн юм амандаа дүүрэн сорж авах; *сүү балгах; архи балгах;* **балгах дуртай** (архи уух дуртай).

БАЛГУУЛАХ балгахын үйлдүүлэх хэв; бага сага юм уулгах; *цай балгуулах.*

БАЛДАРГАНА балчиргана.

БАЛИАМ ортоомоос төрсөн үхэр.

БАЛИАР 1. бохир, заваан; *балиар газар;* 2. болхи бүдүүлэг; *балиар хийцтэй.*

БАЛИАРТАХ балиар болох, болхи байдал гаргах; *нэг согтуу хүн балиартаж байв.*

БАЛИАРТУУЛАХ балиартахын үйлдүүлэх хэв; балиар болгох.

БАЛИУС ерийн хутганаас өргөн том хутга.

БАЛЛАХ 1. балрахад хүрүүлэх; *самбар дээр бичсэнээ баллав;* 2. шилжсэн сүйтгэн бусниулах; *дээрэмчин ирж балласан ажээ;* 3. муу хорт явдлыг нуун далдлах; *мөрөө баллах; хийсэн хэргээ баллах.*

БАЛЛУУЛАХ 1. баллахын үйлдүүлэх хэв; 2. баллагдах; *би баллуулах шахав.*

БАЛЛУУР бичсэн зурсан зүйлийг баллах юм, балчуур ч гэнэ.

БАЛМАГДАХ айн сүрдэх, сандран тэвдэх, сочмогдох; *балмагдаад дуугарч ч чадсангүй; балмагдсан гөрөөс зугатаж чадахгүй.*

БАЛМАГДУУ аймтгай, тэвдэмтгий, сандрамхай.

БАЛМАД хэрцгий, танхай, тэнэг, шудрагагүй; *балмад явдал; балмад байдал; балмад зан.*

БАЛМАДЛАХ хэрцгий балмад байдал, танхай авир зан гаргах.

БАЛНАД гэдэсний халдварт халуун хижиг.

БАЛРАГДАХ 1. балрах; 2. балрахын үйлдэгдэх хэв.

БАЛРАХ 1. балархай болох, харагдахгүй, тодорхой биш болох; *харандаагаар бичсэн нь баларчээ;* 2. үрэгдэн сүйдэж үгүй болох; *эрт нэгэн хот байсан нь баларчээ; айл гэр балрах.*

БАЛРАШГҮЙ балрах шинжгүй, арилах шинжгүй.

БАЛРУУЛАХ 1. балрахын үйлдүүлэх хэв; 2. баллах.

БАЛТ I 1. сүхийн өөр нэр; 2. лантуу.

БАЛТ II бал бүхий юм; **балт зөгий** амьтан (цэцгийн шүүсийг бал болгон боловсруулах нисэх шавьж; хөх түрүүтэй адилавтар өнгө шаравтархан); **балт туулайн бөөр** ургамал (туулайн бөөртэй адил хэлбэртэй жимс, амт сайн, удаан хадгалж идвэл сүүдэр өвчнийг анагаахад тустай гэдэг).

БАЛТАГ хутга илдийн ишний хуйд тулах тулгуур төмөр.

БАЛТАЙ 1. бал бүхий юм; 2. балагтай.

БАЛТАЙЛГАХ балтайхын үйлдүүлэх хэв; балтгар болгох.

БАЛТАЙХ навтайх, атийх, бөхийх зэргээр балтгар болох.

БАЛТАЛЗАХ балтгар юмны байн байн хөдлөх.

БАЛТАРГАНА балчиргана.

БАЛТАС: балтас балтас хийх балтгар юмны байн байн хөдлөх.

БАЛТАЧ шувууны шинхгийн ноолуур үс ургасан өчүүхэн түнтгэр газар.

БАЛТГА: балтга балтга хийх балтгар юмны үргэлжлэн хөдлөх.

БАЛТАЛЗАХ балтас балтас хийх.

БАЛТГАНАХ балтгар юмны балтга балтга хөдлөх байдал.

БАЛТГАР өргөн бүдүүн бөгөөд намхан, навтгар пагдгар; *тарвага шиг балтгар; балтгар уул.*

БАЛТГАРДАХ хэтэрхий балтгар болох.

БАЛТДАХ балтаар цохих.

БАЛУУ ургамал харвар модны адил иштэй, нүцгэн ховлын адил навчтай, нилээд бүдүүн, 3—4 метр өндөр, цагаан судалтай нарийн цул мод, үүний үрийг балуу гэдэг, эмэнд хэрэглэдэг.

БАЛХАЙЛГАХ балхайхын үйлдүүлэх хэв; балхгар болгох.

БАЛХАЙХ балхгар болох.

БАЛХАЛЗАХ балхгар амьтны балхас балхас хийх байдал.

БАЛХАС: балхас балхас хийх балхгар юмны байн байн хөдлөх.

БАЛХГА: балхга балхга хийх; балхгар юмны үргэлжлэн хөдлөх.

БАЛХГАНАХ балхгар юмны балхга балхга хийх байдал.

БАЛХГАР бие намхан бөгөөд өргөн бүдүүн; *балхгар тарган шар.*

БАЛЦАЙХ балцгар болох.

БАЛЦАЛЗАХ балцгар юмны балцас балцас хийх байдал.

БАЛЦАС: балцас балцас хийх балцгар юмны байн байн хөдлөх.

БАЛЦГА: балцга балцга хийх балцгар юмны үргэлжлэн хөдлөх.

БАЛЦГАНАХ балцгар юмны балцга балцга хийх бэйдал.

БАЛЦГАР жижиг амьтны бие баацгар буюу гар хөл өргөн бөгөөд богино махлаг.

БАЛЧИГ 1. угийн шавартай, хуурай болохгүй шигдэх газар; 2. ш и л ж с э н бохир бургаг.

БАЛЧИГДАХ балчиг ихтэй учир тохиромжгүй болох.

БАЛЧИГНАХ ус шавартай газраар явахад шалчиг балчиг хийх.

БАЛЧИГНУУЛАХ балчигнахын үйлдүүлэх хэв.

БАЛЧИГТАХ балчигтай болох, балчиг тогтох.

БАЛЧИН 1. нумны бариулын хоёр этгээд дахь илэг хадах газар; 2. зэмсэг хадаагүй; хазаар худраганы оосор; 3. дээлийн туурайг залган жүрам журмаар илүүдсэн газар; 4. дэмий чамин ярьдаг хүн.

БАЛЧИР нас бага, нялх; *балчир хүүхэд; балчир томоогүй.*

БАЛЧИРДАХ нас балчрын учир тохиромжгүй болох тулгардах, томоогүйдэх.

БАЛЧИРГАНА у р г а м а л дүгрэт түрүүтний нам; хангайн хөвд газар, ихэнхдээ уул хярын жалга судагт ургана, гоньд шиг үртэй, баавгай гөрөөс иднэ.

БАЛЧИХ I хүнийг их л ичээх.

БАЛЧИХ II байн байн баллах.

БАЛЧИХ III бульхайлах зайлуулах байдал гаргах; *бурууга балчих гэж ядаж байв.*

БАЛЧУУ мяндсаар нэхэж хийсэн чисчүүтэй адилавтар нэг зүйл торгомсог бараа.

БАЛЬДАХ I балгадуу элбэгжүү байдал гаргах.

БАЛЬДАХ II маш ядарч хөл туйвалзах.

БАЛЬДУУ балгадуу, элбэгжүү.

БАМ чийг өвчин; **чийг бам х о р ш..**

БАМБАГА: бамбага бамбага хийх бамбагар юмны үргэлжлэн хөдлөх.

БАМБАГАНАХ бамбагар юмны бамбага бамбага хийх байдал; *бамбалзуур газар бамбаганана; орны пүрш бамбаганана.*

БАМБАГАНУУЛАХ бамбаганахын үйлдүүлэх хэв.

БАМБАГАР зөөлөн бөгөөд зузаан хөвсгөр; *бамбагар уруул; бамбагар ширдэг.*

БАМБАЙ I 1. зузаалж хийсэн гудас дэвсгэр; 2. зузаан жийрэг; *хомын бамбай.*

БАМБАЙ II 1. хатгах чавчих зэргээс хамгаалах урьдын цагийн цэргийн зэвсгийн зүйл, дугуй дөрвөлжин янз бүр байдаг; 2. төмөр замын вагон зэрэгт хоорондоо мөргөлдөхөд доргих хүчийг сулруулах тусгай хэрэгсэл; 3. байлдахад урьдчилан оруулах буюу халхавч болгон оруулах цэрэг; 4. ш и л ж с э н халхавч хамгаалал; **бамбай барих** (түрээ барих; *эрх тушаалын хүнээр бамбай барив);* ☆ **бамбай булчирхай** (хоолойны тус газар байдаг булчирхай); **бамбай мөгөөрс** (хоолойн тус газар байдаг том мөгөөрс).

БАМБАЙ III у р г а м а л ягаавтар цэцэгтэй, нугын өвсөрхөг ногоо; үнэр сайхан, үндсээр нь эмийн ханд хийнэ.

БАМБАЙЛАХ 1. юмыг зузаалж бамбагар болгох; 2. тэмээний хомонд бамбай барих; 3. ш и л ж с э н эсэргүүцлийн этгээдэд ямар нэгэн юмаар бамбай болгох.

БАМБАЙЛГАХ бамбайхын үйлдүүлэх хэв; бамбагар болгох.

БАМБАЙЛУУЛАХ бамбайлахын үйлдүүлэх хэв.

БАМБАЙХ бамбагар болох; *дэвсгэр бамбайгаад байна, нимгэсгэе.*

БАМБАЙЧ 1. бамбай барьдаг; 2. бамбай баримтгай; 3. бамбайн цэрэг.

БАМБАЛЗАХ бамбагар юмны бамбас бамбас хийх байдал.

БАМБАЛЗУУЛАХ бамбалзахын үйлдүүлэх хэв.

БАМБАЛЗУУР 1. намаг дэнэлзүүр газар, байх явах гишгэхэд хонхолзон хөдлөх газар; *бамбалзуур газар;* 2. бамбалздаг юм; *бамбалзуур сандал.*

БАМБАРУУШ бамбарш.

БАМБАРШ баавгайн зулзага.

БАМБАС: бамбас бамбас хийх бамбагар юмны байн байн хөдлөх.

БАМИН а м ь т а н заантай адилавтар бөгөөд хөл нь охор, биедээ бидэр хайрстай, хамрын үзүүрт нэг эвэртэй нэгэн зүйл гөрөөс.

БАМТАХ I чийг бам өвчнөөр өвдөх.

БАМТАХ II айн бэрхшээх, тэвдэх; *юунд сүрдэж бамтав?*.

БАНАЦАН у р г а м а л навч хөлдсөн ч зулгардаггүй, амтайхан жүржийн адил цэцэгтэй, цөмөө ногоон, амт сайхан тослог бөгөөд шандууралтай, тос нь загатнахад тустай нэг зүйл жимс.

БАНБАР хөвөн, бөс мэтэд тос шингээн модны үзүүрт ороож, түүнд гал авалцуулан гэрэлтүүлэх, юм халаах хэрэгсэл.

БАНБАРДАХ банбар асааж гэрэл гаргах буюу юмыг төөнөн халаах.

БАНБАРЛАХ банбар хийх.

БАНД I у р г а м а л мод цэцэглэхгүй, жимс нь үндэснээс үзүүрт хүртэл, цөм модны хальсанд нь ургадаг, жүржийн адил том нэг зүйл жимс.

БАНД II у р г а м а л вандуйн нэг зүйл.

БАНДАЙХ бандгар болох, таргалах, зузаарах.

БАНДАЛЗАХ бандгар юмны бандас бандас хийх байдал.

БАНДАН урт банз буюу нарийн модоор хийсэн дөрвөн хөлтэй ширээ мэт хэрэгсэл; *мужааны бандан; суудаг бандан; бандан ширээ.*

БАНДАС: бандас бандас хийх бандгар юмны байн байн хөдлөх.

БАНДГА: бандга бандга хийх бандгар юмны үргэлжлэн хөдлөх.

БАНДГАНАХ бандгар юмны бандга бандга хийх; *тарган хонины сүүл бандганаж явна.*

БАНДГАР зузаан, тарган; *бандгар сүүлтэй хонь; бандгар тарган хүн.*

БАНДИ буддын шажны ёсны анхан шатны сахилтан.

БАНДИД мэргэн, буддагийн шажны ёсны таван ухааны номд мэрэгжсэн хүнд олгох цол.

БАНЖ хүүхэд багачуудад сэрэмжлэн болгоомжил гэж урьдчилан сануулахад хэрэглэнэ.

БАНЖИХ хэрэглэгдэхүүнийг төхөөрөн бэлдэх, зэхэх.

БАНЗ I нимгэлэн зүссэн урт хавтгай мод.

БАНЗ II урьдын цагт хүнийг зодох хэрэгсэл; *ширэн банз; хулсан банз.*

БАНЗАЛ хүний бөгсөн биед өмсөх нэг зүйл хувцас.

БАНЗДАХ банзаар жанчих.

БАНЗДУУЛАХ 1. банздахын үйлдүүлэх хэв; 2. банздагдах.

БАНЗЛАХ 1. банз болгох; 2. уст арьсны зүйлийг банзанд ороож толируулах; *арьс банзлах.*

БАНТАГНАХ 1 .бантан хийх; *гурил бантагнах;* 2. хольж хутгах, будлиантуулах; *бантагнасан ажил болж дээ!.*

БАНТАГНУУЛАХ бантагнахын үйлдүүлэх хэв.

БАНТАЙХ бантгар болох.

БАНТАН 1. багсарсан гурил үрж буцалгасан шөл; 2. ш и л ж с э н будлиантсан хутгасан зүйл; **холио бантан** (будлиантай самууралтай); **бантан хутгах** (хутган будлиантуулах, самууруулах).

БАНТГАР тарган, махлаг, тантгар.

БАНУ агуйн дээврээс монцоглож унжин тогтсон шохойн чулуулаг, үнээн хөх ч гэнэ.

БАНУНЦАР газарт унасан буюу сарнин бутарсан бану.

БАНУУХАЙ а м ь т а н өдрийн наранд усанд оршино; шөнө голын ирмэгт хэвтэнэ, өнгө адилгүй, хар нь маш ховор нэгэн зүйл амьтан.

БАНХАЙЛГАХ банхайхын үйлдүүлэх хэв; банхгар болгох .

БАНХАЙХ банхгар болох.

БАНХАР амьтны хушуу бүдүүн богино.

БАНХАС үнэт чулуулаг, зэ хас ч гэнэ.

БАНХГАР банхар.

БАНШ татсан махыг гурилд боож усанд буцалган идэх нэг зүйл хоол.

БАР I усан дорхи элс бүхий газар.

БАР II 1. ном бичиг, зураг хөрөг дармаллан хэвлэх сийлмэл хэв; *барын ном; төвд номын бар;* 2. хэвлэхэд хэрэглэх төмөр чулуу мод зэрэг дээр гаргасан зураг; *физикийн сурах бичигт хэрэглэх барууд.*

БАР III барс; **эр бар** (чадал хүчтэй); **би чамдаа эр бар** (би чамайг амар дийлнэ).

БАР IV: **бар бар** дуу дууриасан; *бараан дороо орж бар бар* үлгэр; *бар бар дуугарах.*

БАРАА I 1. нэхэж сүлжиж үйлдвэрлэсэн эд бөс; *барааны дэлгүүр; бараа гүйлгээ; бараа таваар;* 2. айлын гадна хураасан элдэв юм; **гэр бараа** хорш.. ᠪᠠᠷᠠᠭ᠎ᠠ

БАРАА II 1. юмны үзэгдэх овор байдал; *бараа ихтэй;* **хүний бараа** (хань гэж дэргэдээ байлгах); **бараа туруугүй** (үзэгдэх харагдах юмгүй); 2. алсаас харахад үзэгдэх дүр дүрс; **барааны газар** (нилээд хол; *барааны газраас бархирав); хотын бараа харагдав; бараа бараагаа харан зөрөв;* 3. шилжсэн ирэх, ойртох; **гэрийн бараа харахгүй болох** (гэртээ ирэхээ болих); *зэрлэгшсэн нохой хүний бараа харахгүй болжээ;* 4. ойролцоо дэргэд байх; **бараа болоочин** (ихсийг дагаж үйлчлэн явагчид); **бараа болох** (ихсийг дагаж үйлчлэн явах). ᠪᠠᠷᠠᠭ᠎ᠠ

БАРААВТАР баахан бараан. ᠪᠠᠷᠠᠭᠠᠪᠲᠠᠷ

БАРААГНАХ 1. барайн харагдах, барайх; 2. дотор харлах; *дотор бараагнах.* ᠪᠠᠷᠠᠭᠨᠠᠬᠤ

БАРААГҮЙ I 1. оргүй, үзэгдэх юмгүй; *бараа туруугүй.* ᠪᠠᠷᠠᠭ᠎ᠠ ᠲᠤᠷᠤᠭᠤᠢ

БАРААГҮЙ II дуусгавргүй; *намайг хоолоо идэж бараагүй байхад ....* ᠪᠠᠷᠠᠭᠠᠭᠤᠢ

БАРААДАХ I 1. дагаж ойролцоо явах; *эцэнхий даага, адуу бараадаж явна;* 2. түшиглэх; *хамаатан садныа бараадах хэрэгтэй болжээ; хот бараадаж суув.* ᠪᠠᠷᠠᠭᠠᠳᠠᠬᠤ

БАРААДАХ II хэтэрхий бараан болох.

БАРААЛАХ 1. бараан болох, харлах; *газар бараалах;* 2. бараан болгох. ᠪᠠᠷᠠᠭᠠᠯᠠᠬᠤ

БАРААЛУУЛАХ бараалахын үйлдүүлэх *хэв.* ᠪᠠᠷᠠᠭᠠᠯᠠᠭᠤᠯᠬᠤ

БАРААЛХАХ хүндэтгэвэл зохих эрхэм хүнтэй бие тулж уулзах учрах. ᠪᠠᠷᠠᠭᠠᠯᠬᠠᠬᠤ

БАРААЛХУУЛАХ бараалхахын үйлдүүлэх хэв. ᠪᠠᠷᠠᠭᠠᠯᠬᠠᠭᠤᠯᠬᠤ

БАРААН хар; **хар бараан** хорш.; бүгээн, цагаан байхгүй; *бараан зүсмийн мал харагдав;* **бараан цай** (хар цай); *бараан өнгийн эд;* **бараан шувуу** (хэрээний өөр нэр); **бараан хавтгалж** амьтан (нуга, намагт оршдог, толгойдоо хөхөлтэй, хүнд нь 200 грамм хүрдэг нэг зүйл шувуу); **бараан гялтгануур** (өнгө нь бараавтар, галд хийхэд хөвсийдөг, сайтар нунтаглавал шар өнгийн будаг болдог нэг зүйл чулуулаг). ᠪᠠᠷᠠᠭᠠᠨ

БАРААНДАХ хэтэрхий бараан болох. ᠪᠠᠷᠠᠭᠠᠨᠳᠠᠬᠤ

БАРААНДУУ нилээд бараан. ᠪᠠᠷᠠᠭᠠᠨᠳᠤᠭᠤ

БАРААНТАХ бараан болох; *газар бараантах;* **эрээнтэх бараантах** хорш.. ᠪᠠᠷᠠᠭᠠᠨᠲᠠᠬᠤ

БАРААТАЙ том, бараа ихтэй; *бартаатай уул.* ᠪᠠᠷᠠᠭ᠎ᠠᠲᠠᠢ

БАРААХАН бараандуу. ᠪᠠᠷᠠᠭᠠᠬᠠᠨ

БАРАГ I ямар нэг юм болоход тун ойртсоныг заана, ихэвчлэн; *бараг шөнө болов; бараг гүйцэв;* **тэр ч бараг даа** (тэр ч гавихгүй гэж чамласан саная); **баргийн юм дийлэхгүй** (ихэнх юм дийлэхгүй); **бараг төлөв** (их төлөв); ☆ **бараг сүүдэр** (тарлан нартай сүүдэр); **бараг бүрэг** (баруй бүрүй). ᠪᠠᠷᠠᠭ

БАРАГ II газрын хэмжээ нэгэн үрийг арав хуваасны нэг.

БАРАГДАХ барахын үйлдэгдэх хэв; дуусах; *мал барагдахад богтос ахлах* зүйр; *арга барагдах; зуурсаар байтал шавар нь барагдав.* ᠪᠠᠷᠠᠭᠳᠠᠬᠤ

БАРАГДАХГҮЙ дуусахгүй, арвин их. ᠪᠠᠷᠠᠭᠳᠠᠬᠤ ᠲᠦᠭᠰᠦᠬᠦᠢ

БАРАГДАШГҮЙ барагдах шинжгүй, маш их; *барагдашгүй баян, үгүйршгүй мөнх.* ᠪᠠᠷᠠᠭᠳᠠᠵᠤ ᠲᠦᠭᠰᠦᠬᠦᠢ

БАРАГДУУЛАХ барагдахын үйлдүүлэх хэв. дуусгах. ᠪᠠᠷᠠᠭᠳᠠᠭᠤᠯᠬᠤ

БАРАГЛАХ 1. ихэвчлэн, гүйцэх, дуусах; *ажлаа бараглаж байна, удахгүй гүйцнэ;* 2. барагцах, багцах, багцаалах; *би бараглаж мэдсэн.* ᠪᠠᠷᠠᠭᠯᠠᠬᠤ

БАРАГЛУУЛАХ бараглахын үйлдүүлэх хэв; дуусгуулах. ᠪᠠᠷᠠᠭᠯᠠᠭᠤᠯᠬᠤ

БАРАГТАЙ 1. гайгүй, овоо; *өвдөх нь барагтай байна; биднийг гарахад голын ус барагтай байв; барагтай бол ирнэ;* 2. муухан; *борoо салхитай барагтай өдөр; чанараар барагтай эд;* 3. зүгээр, томоотой; *барагтай байгаарай!* ᠪᠠᠷᠠᠭᠲᠠᠢ

БАРАГТАЙВТАР нилээд барагтай. ᠪᠠᠷᠠᠭᠲᠠᠢᠪᠲᠠᠷ

БАРАГТАЙХАН муухан; *бие барагтайхан байв;* **барагтайхан ааштай** (нилээд муухай ааштай). ᠪᠠᠷᠠᠭᠲᠠᠢᠬᠠᠨ

БАРАГЦАА багцаа, тойм, баримжаа. ᠪᠠᠷᠠᠭᠴᠠ᠎ᠠ

БАРАГЦААЛАХ багцаалах, тоймлох, баримжаалах, бүдүүвчлэх. ᠪᠠᠷᠠᠭᠴᠠᠭᠤᠯᠬᠤ

БАРАГЦААХ багцаалах, тоймлох, бүдүүвчлэх. ᠪᠠᠷᠠᠭᠴᠠᠭᠤᠯᠬᠤ

БАРАГЦАХ бараглах, багцаалах, тоймлох. ᠪᠠᠷᠠᠭᠴᠠᠬᠤ

БАРАГШИН хадын хайлмал, гудамж, засмал зам зэргийг цардах давирхайлаг хар зүйл.

БАРАГШИНДАХ гудамж, засмал зам зэргийг барагшингаар цардах; *барагшиндсан зам.*

БАРАЙЛГАХ барайхын үйлдүүлэх хэв; *царайгаа барайлгаж ийн хэлрүүн ....*

БАРАЙХ баргар болох, аягүй тийшээ хувирах; *царай нь барайв; тэнгэр барайж байна, бороо орох нь.*

БАРАЛЗАХ байн байн барайх, ичингүйрч нүүр улайх; *нүүр баралзах.*

БАРАМ I ш а ш и н золиосонд гаргах юм.

БАРАМ II: **үл барам**; тэр байтугай, тэр ч юу ч биш.

БАРАМНАС үүд цонхны завсраас гялбалзсан нарны гэрэлд жирвэлзэн үзэгдэх хумхи, тоос.

БАРАНЖАЙ шажны ёсны бурханд тахил болгон хийсэн нэгэн зүйл балингийн дүрслэл.

БАРАС: барас бүрэс нэг үе мэдэж, нэг үе мэдэхгүй байх бас нүдэнд асар тодорхойгүй үзэгдэх; *ухаан барас бүрэс болов; харанхуйд нэг юм барас бүрэс хийв.*

БАРАСХИЙХ түр зуур барайх.

БАРАХ 1. дуусах, дуусгах; *аянд явсан хүн хоолоо баржээ; зудад малаа барсан айл; аягатай хоолоо баралгүй тавив;* **нас барах, бие барах** (үхэх); 2. чадах, дийлэх; *бичиж барах; хийж барах.*

БАРАХАЙ а м ь т а н барстай адилхан, гахайн үс шиг үстэй, эрээн магнайтай нэгэн зүйл гөрөөс; ашиг цулцан гэдэг өвчнийг засахын тул махы нь иддэг.

БАРАХГҮЙ чадахгүй, дийлэхгүй, давахгүй, амжихгүй; *энэ толгой чинь барахгүй, цадахгүй хоол байна!*

БАРВАГАР арьс хөрсний зузааран хөрсийсөн, бамбагар зузаан буюу бүрсгэр юм, болхи бүдүүлэг юм; *барвагар хөрс; барвагар дээвгэр; барвагар уруул; барвагар хийцтэй эд.*

БАРВАЙЛГАХ барвайхын үйлдүүлэх хэв.

БАРВАЙХ барвагар бамбагар болох.

БАРГА Монголын нэгэн аймаг үндэстэн; ☆ **барга малгай** (урьдын цагт шашны дээд тушаалтан лам нарын өмсч байсан нэгэн зүйл дугуй хэлбэртэй, үстэй малгай; Өндөр гэгээн анх зохион гаргасан гэдэг).

БАРГАР өнгө зүс хувирч бүрзгэр аягүй болсон нь; *өвчтэй учир царай нь баргар байжээ; тэнгэр баргар байна, салхилж магадгүй.*

БАРГАХ тэнгэр бүрхэж, цас орохуяа завдан, үе үе манаран үе үе намдах; *тэнгэр баргах;* бургах ч гэдэг.

БАРГИА 1. дэмий ярих дуртай; 2. бүдүүн царгиа дуун; *баргиа дуун; баргиа хоолой.*

БАРГИЛТ өнгө цагаан шаравтар буюу цэнхэр, юм урлан хийхэд зөөлөн нэг зүйл чулуулаг; *баргилт чулуу.*

БАРГИУЛАХ баргихын үйлдүүлэх хэв.

БАРГИХ баргиа болох; *хоолой баргих.*

БАРДААГААР лавтай, бардам; *бардаагаар чадна.*

БАРДАГ балдаг.

БАРДАГНАХ бардах; бардам зан гаргах.

БАРДАМ биеэ бусдаас илүүтэй болгон дээрэнхүйлэх зан ааль; *согтуу хүн ам бардам; бардам дээрэнгүй;* 2. бардаагаар.

БАРДАМЛАХ бардам зан байдал гаргах.

БАРДАМТГАЙ бардах дуртай.

БАРДАН бардам

БАРДАХ бардам дээрэнгүй зан байдал гаргах; *их бардах муу; сайн бөх бардаж яваад* ойчив; *бардах нь биш ....*

БАРДУУЛАХ бардахын үйлдүүлэх хэв.

БАРЖГАР барзгар; *баржгар дурдан.*

БАРЖИЙЛГАХ баржийхын үйлдүүлэх хэв; баржгар болгох.

БАРЖИЙХ бэржийх, баржгар болох.

БАРЗАЙЛГАХ барзайхын үйлдүүлэх хэв.

БАРЗАЙХ барзгар болох; *хатаад барзайчихлаа; шарилж бут барзайн харагдав.*

БАРЗАН I барзгар, хиртсэн, сэвхтсэн нь үлэмж; *барзан толь; барзан нүүртэй хүн.*

БАРЗАН II барилгад хэрэглэх нэг талы нь дөрвөн цавчаас гаргаж үйлдсэн чулуу; чулуу шохой цемент зэргээр хийдэг.

БАРЗАНТАХ хиртэх, сэвхтэх зэргээр барзан тогтох; барзантай болох.

БАРЗГАР өө сэв ихтэй, арзгар; **арзгар барзгар** х о р ш . .

БАРИ цагаан өнгөтэй зөөлөн төмөрлөг.

БАРИА I 1. барьцаа, **бариа барих** (а. бусдаас авах өр төлбөрийн оронд эд юмыг барьцаалан авах; б. зээлдүүлсэн мөнгийг буцааж өгтөл эд хөрөнгийг данж болгон барьж байх); 2. бэлэн худалдаалах хоёр хүн хоорондоо юмаа бэлнээр өгч авалцах наймаа.

БАРИА II морь, тэшүүр, цанын уралдааны пайз олгох төгсгөлийн газар; *барианы газар; бариand орох.*

БАРИА III: **ясан барна** яс маш их шимшрэн өвдөх өвчин.

БАРИАЧ яс бэртсэн зэргийг барилан засагч; ☆ **бариач уран** (барималч хүн; барилчин); **морь бариачин** (уралдааны морьд давхин прэхэд дэс дараагаар цулбуурдан пайз олгох хүмүүс).

БАРИАЧЛАХ яс бэртсэн зэргийг барилан засах.

БАРИАЧЛУУЛАХ бариачлахын үйлдүүлэх хэв.

БАРИВЧЛАГДАХ баривчлахын үйлдэгдэх хэв; *баривчлагдсан этгээд зугадахыг завдав.*

БАРИВЧЛАХ хүнийг сул дурааараа явж үл болох ба болгох, гянданд хорих; *хуулийн газраас баривчлав; хулгайчийг баривчлах;* ☆ **хулгай баривчлах** (а. хулгайлсан этгээдийг барих; б. ш и л ж с э н бусдыг мэхлэснийг олж илрүүлэх).

БАРИВЧЛУУЛАХ баривчлахын үйлдүүлэх хэв.

БАРИГДАХ I. барихын үйлдэгдэх хэв; 2. эзлэгдэх; *бөөсөнд баригдах; зовлонд баригдах;* ☆ **нар баригдах** (нар хиртэх).

БАРИГЧ ямар нэг юмыг барьдаг буюу барьсан этгээд; *эрх баригч; эх баригч.*

БАРИЛ 1. барих газар, барьц; *барилаа олж барилдах;* 2. арга зам; *барилы нь олох;* **барил дадал** х о р ш . .

БАРИЛАХ байн байн барих.

БАРИЛГА I байшин сав зэрэг барьж үйлдэх бүх зүйл; *барилгын хэрэг эрхлэх газар; барилгын маяг; барилгын ухаан; барилгын ажилчин; манай нийслэл өндөр сайхан барилгуудтай болов;* ☆ **уран барилга** (барилгын урлал); **барилга барих** (орон байшин барих); **уран барилгач** (байшин барилга барих мэрэгжилтэй хүн); **их барилга** (фабрик, завод, цахилгаан станц, уурхай, төмөр зам, суваг, орон сууцны барилга, эмнэлэг, сургууль зэрэг шинэ барилга); **их барилгын төлөвлөгөө** (их барилга барих төлөвлөгөө).

БАРИЛГА II х у у ч и р с а н лам нарт барьж өгөх юм.

БАРИЛГАЧИН барилга барих ажилчин; *манай барилгачдын их бүтээл.*

БАРИЛДАХ 1. наалдан зууралдаж салгахад хэцүү болох; *барилдан хөлдөх;* 2. ноцолдон тэнхээгээ сорих; *наадам эхлээд бөх барилдаж байлаа.*

БАРИЛДЛАГА 1. учрал, тохиол; 2. зурхайн ёсны од гаригийн тохиол; 3. бат холбоо; *ах дүүгийн барилдлага.*

БАРИЛДУУЛАХ барилдахын үйлдүүлэх хэв.

БАРИЛУУЛАХ барилахын үйлдүүлэх хэв.

БАРИМ уртын барагцаалсан хэмжээ, урт юмыг гарын царвуугаар нэг удаа атгаж авсныг нэг барим гэнэ.

БАРИМАЛ юмны дүрс хэлбэрийг сийлэх, цутгах, барих зэргээр үйлдэн бүтээх нэг зүйл урлаг; *уран баримал.*

БАРИМАЛЧ баримлын урлалд мэрэгжсэн хүн; *уран барималч.*

БАРИМЖАА хир багцаа, тойм; *газрын баримжаагаар олж ирэв; нэг өртөөний баримжааны газар; төөрч баримжаагаа алдах.*

БАРИМЖААЛАХ тоймлох, барагцаалах, баримжаагаар дүрслэх; *жин байхгүй учраас баримжаалж авав; өндөр уулыг баримжаалан явлаа.*

БАРИМЖААЛУУЛАХ баримжаалахын үйлдүүлэх хэв.

БАРИМТ 1. гэрч, бат болох юм, үнэмлэх тэмдэг; *бариmттай хэрэг; хэргийн баримт; эд мөрийн баримт; хойч өдөр баримт болгох;* 2. үнэмшүүлэх бичиг, хуудас, албан газар зэргээс юм хүлээж авахад гаргах хуудас; *баримт бичиг хүлээж авлаа; нүүрсний баримт.*

БАРИМТАТ баримт бүхий юм; *баримтат кино; баримтат зүйл.*

БАРИМТГҮЙ баримтлах юмгүй; *бичиг баримтгүй; иш баримтгүй.*

БАРИМТЛААЧ зүтгээ, хөшүүн.

БАРИМТЛАГЧ ямар нэг зүйлийг зөв гэж үздэг; *шажингүй ёсыг баримтлагч; тэр талыг баримтлагч.*

БАРИМТЛАЛ итгэж тулгуурласан санаа.

БАРИМТЛАХ ямар нэг зүйлийг зөв үнэнд үзэх, дагах; *марксизмыг баримтлах; хэв заншлыг баримтлах; дүрэмд заасныг баримтлан дагах.*

БАРИМТЛУУЛАХ баримтлахын үйлдүүлэх хэв.

БАРИН: барин тавин хийх, баримагц хийх, зав чөлөөнд хийх; ☆ **барин тавин худал хэлэх** (ичгүүр сонжуургүй худал хэлэх); **барин тавин хэлэх** (бэлэн зэлэн хэлэх).

БАРИНТАГ хуучирсан I. дээл хувцасны хүндэтгэл; 2. шажны номыг боох ваадан; *номын баринтаг.*

БАРИНТАГЛАХ хуучирсан 1. эрхэм хүний дээлээ өмсөх; 2. номыг баринтагт босх; 3. шилжсэн том мөрөн голын ус гүйцэд хөлдөх.

БАРИНТАГЛУУЛАХ баринтаглахын үйлдүүлэх хэв.

БАРИУ хувцасны давч; *бариу ханцуйтай дээл.*

БАРИУВЧ бага хүүхдийн дээл.

БАРИУДАХ хэтэрхий бариу болох.

БАРИУДУУЛАХ бариудахын үйлдүүлэх хэв.

БАРИУЛ 1. аливаа юманд барихад зориулж хийсэн иш, гогцоо, сэнж; *данхны бариул; хаалганы бариул;* 2. юмыг барихад жийрэг болгон хэрэглэх зүйл; *тогооны бариул.*

БАРИУЛАХ барихын үйлдүүлэх хэв; **машин бариулах** (машин жолоодуулах); **түр бариулах** (юмыг түр зээлдүүлэн хэрэглүүлэх); **мөнгө бариулах** (зарцуулах мөнгийг тушаан эзэгнүүлэх); **яс бариулах** (а. яс бэртсэнийг илбэн засуулах; б. үхэгсдийг оршуулахад үхдэлд гар хүргүүлэх); **хүний гараар могой бариулах** (муу үйлийг дам, хүнээр үйлдүүлэх).

БАРИУТАХ улам бариу болох.

БАРИУТГАХ бариутахын үйлдүүлэх хэв; бариу болгох.

БАРИУХАН нилээд бариу, баахан бариу.

БАРИХ 1. юмыг гартаа атгаж авах; *хүүхдийн гараас барих; туг барих;* 2. юмыг гартаа оруулж сул явахгүй болгох; **алдуул мал барих** (алдуул малыг эзэмдэн авч байх); **гүү барих** (унагыг уяж, гүү сааж айраг хийх): **морь барих** (а. морийг унах эдлэхээр барин авах; б. уралдаанд морийг барианы газар ирэхэд барин авч пайз олгох); **унаа барих** (морь, тэмээ зэрэг унах малыг барин авах); **бэртэнгийг барих** (бэртсэн гэмтсэнийг илж засах): ☆ **лаа барих** (лаа асаах); **гэрэл барих** (гэрэл асаах); **зул барих** (зул асаах); **гэр барих** (гэрийг цогцлон байгуулах): **барилга барих** (барилгыг бүтээн цогцлох); **байшин барих** (байшинг цогцлон бүтээх); **түр барих** (юмыг түр зээлдэн хэрэглэх; *танай ширээг түр барьж байгаад өгье);* **хөгжим барих** (а. ямар нэгэн хөгжмийг тоглож чаддаг; *тэр хүн ятга хөгжим барьдаг;* б. ихэс дээдэст хөгжимдөж сонирхуулах); **барих газар** (барианы газар); **бариа барих** (өр төлбөрийн оронд эд юм хүчдэн авах); **барьцаа барих** (зээл өгөхдөө оронд нь данж болгож юм авч хадгалах); **тогоо барих** (гэрийн ажил хийх); **холбоо барих** (хоёрын хооронд харилцан шижим болж ажиллах); **мэдээ барих** (бусдад хэл мэдээ хүргэх); **барьж идэх** (а. ноцож амийг таслан идэх; *чоно, тарвагыг барьж идэв;* б. сүрхий уурсан нэхэж, шаардан давшлах; *түүнийг олон хүн барьж идэх шахав);* **барьц барих** (барьц өгөх); **билиг барих** (билиг өгөх); **жуух бичиг барих** (жуух бичиг өгөх); **дугараа барих** (найр цэнгэлд айраг архийг нийтэд хүрэлцүүлэх); **дээж барих** (идээ ундааны дээжийг хүндэтгэвэл зохих хүнд түрүүлэн өгөх); **зоог барих** (ихэс дээдэст идээ ундаа өгөх): **машин барих** (машин жолоодох); **эрх барих** (толгойлох); **жолоо барих** (удирдах); **мөнгө барих** (мөнгийг эрхлэн зарцуулах); **талх барих** (талх хийх); **ам барих** (ямар нэгэн үйл явдалд хожимдон харамсах); **биеэ барих** (ямар нэгэн үйл ажилд болгоомжлох); **сэтгэлээ барих** (санааширсан үйл явдлыг мартагнахыг хичээх); **түрээ барих** (ямар нэгэн үйл ажилд бусдаар бамбай түшиг хийж хэтрэмгийлэх); **ул барих** (урьд өнгөрсөн ажлыг жишээ болгож ажиллах); **улаа барих** хуучирсан (албадан улаа хэрэглэх); **урдаа барих** (толгой тэргүүн, хамгийн сайнд тооцогдох; *ганц урдаа барьдаг хүн маань энэ!);* **хөөр барих** (хийсэн үйл ажилдаа сагсуурч ид бах болгох); **хээл барих** (малын хээл олох); **анд барих** (сайн нөхөр бололцох); **хүж барих** хуучирсан (хоёр хүн ах дүү болох ёс хийх); **элэг барих** (бусдыг

доромжлон дээрэлхэх); **ихийн шийр барих** (ихэмсэг томоотой зан гаргах); **эх барих** (хүүхдийг төрөхөд гардан авах); **яс барих, хүүр барих** (оршуулах хүүрэнд анх гар хүрэх); **нар барих** (нар хиртэх); **сар барих** (сар хиртэх); 3. үйлт нэр, нөхцөл үйлийн зарим төлөвтэй хамтран тухайн үйлийн байдлыг заана; *явах барих нь удаан юм; сууж барих нь сонин юм.*

БАРЛАГ I Монгол овгийн доторхи өөлдийн нэг аймаг.

БАРЛАГ II 1. зарц, боол; 2. хөзрийн боол.

БАРЛАХ барын хэвээр ном, зураг мэтийг дармаллах; *ном барлах.*

БАРЛУУЛАХ барлахын үйлдүүлэх хэв.

БАРМАЙ у р г а м а л мод, өндөргүй боловч маш бүдүүн, навч гилгэр, жимс дүн гуагийн адил том, хальсанд үү, бүлхэн сондуу бий.

БАРОМЕТР агаарын даралтыг хэмжих багаж; *барометрийн хэмжээ.*

БАРС 1. а м ь т а н-муурын адил бидэртсэн эрээн арьстай, сүүн тэжээлт том араатан; 2. сарны зурхайн ёсны арван хоёр жилийн гуравдугаар жилийн нэр; *барс жил;* 3. мөн зурхайн ёсны жил бүрийн хаврын тэргүүн сарын нэр; *барс сар;* 4. мөн зурхайн ёсны өглөөний 3—5 хүртлэх цагийн нэр; *барс цаг.*

БАРСАЙЛГАХ барсайхын үйлдүүлэх хэв.

БАРСАЙХ барсгар болох; *нүүр барсайх;* **арсайх барсайх** х о р ш . .

БАРСГАР арсгар, арзгар, гилгэр тэгш биш; *барсгар хад.*

БАРСГАРДАХ хэтэрхий барсгар болох.

БАРСГАРХАН баахан барсгар.

БАРТАА 1. явахад саад бэрх болох жалга, сархиаг, хад, чулуу зэрэг; *бартаатай зам;* 2. ш и л ж с э н бэрхшээл, саад, төвөг; *ажил хийхэд бартаа их тохиолдоно.*

БАРТААДАХ бартаа ихдэх, хэтэрхий бартаатай болох.

БАРТАГ болхи муу урласан, болхи сэлбэж зассан; *бартаг болгох.*

БАРТАГЛАХ урлах сэлбэх засах зэрэгт цэвэргүй болхи муухай болгох.

БАРТАГЛУУЛАХ бартаглахын үйлдүүлэх хэв.

БАРУЙ бүрий; **харуй баруй, баруй бүрий** х о р ш. үдэш болж юм бараг бүрэг үзэгдэх болох үе.

БАРУР у р г а м а л ус шороо тохирсон дулаан газар ургадаг мод; үр нь мөхлөг, амт эхүүн, дотроо хар хальстай тослог идээтэй эмэнд хэрэглэнэ; **барурын цэцэг** у р г а м а л (иш навч нягт, цэцэг улаан хүрэн хоёр зүйл бий; үр бяцхан, хусын үртэй адил гуравдугаар дөрөвдүгээр сард цэцэглэнэ; аятай үнэртэй).

БАРУУЛ: хэрүүл баруул хэрүүл цуугиан.

БАРУУЛАХ I баруун зүг тийш явах.

БАРУУЛАХ II барахын үйлдүүлэх хэв.

БАРУУЛУУЛАХ баруулах I-ийн үйлдүүлэх хэв.

БАРУУН 1. нар шингэх зүг; *баруун зүг; баруун Европ; голын баруун эрэг дээр; баруун урд; баруун хойт;* 2. ич этгээд; солгойн нөгөө тал; **баруун гар** (ш и л ж с э н шадар хүн, дотно хүн); *баруун мөрөө түрүүлэх;* 3. улс төрийн талаар аливаа давшилтыг үзэн ядах харгис үзэлтэй; *баруун социалистууд бол ажилчин ангиас урвасан этгээдүүд мөн; барууны үзэлтэй; барууны хэлбэрэл.*

БАРУУНШ баруун тийш.

БАРУУНШЛАХ баруулах I.

БАРУУНШЛУУЛАХ барууншлахын үйлдүүлэх хэв.

БАРХАН I говь газар салхинд туугдаж хуралдсан ихээхэн элсэн манхан.

БАРХАН II модон бараар ном бичиг дармаллах хэвлэлийн газар.

БАРХАСБАДЬ пүрэв.

БАРХИРАА хашгирах, орилох дуртай.

БАРХИРАХ хашгирах, орилох; *айн сочин бархирах; хашгирч бархирах.*

БАРХИРУУЛАХ бархирахын үйлдүүлэх хэв.

БАРЦАД гай, саад, зэтгэр.

БАРЦАШ бардаагаар; *тэр барцаш чадна.*

БАРЧ барлагч, бар сийлэгч.

БАРЧГАР барзгар, арзгар.

БАРЧГИР барзгар, арзгар.

БАРЧИЙХ барзайх, арзайх.

БАРШ барагдал, дуусал; *барш сайнтай* **барш ихтэй морь** (газар хороохдоо сайн); **барш муутай морь** (газар хороохдоо муу); **барш багатай ажил** (төвөг ихтэй ажил).

БАРШГҮЙ барагдашгүй, маш элбэг, их; *яндаж баршгүй далай шиг ясан баян нутаг вэл.*

БАРЬЦ I 1. барих газар; *барилдаж байгаа бөх барьцаа алдахгүйг хичээж байв;* 2. шилжсэн бараатай, биетэй, барих газартай; *барьцтай ажил.*

БАРЬЦ II сүсэгтэн этгээдээс мөргөл ном уншуулахад өгөх юм; **өргөл барьц** хорш..

БАРЬЦАА I юмыг зээлэн өгөхөд данж болгон авсан эд юм.

БАРЬЦАА II залгаа, зэргэлдээ, харьцаа газар; **барьцаа өртөө** хуучирсан (харилцан улаа юүлэх нэгэн залгаа өртөө; *баруун барьцаа; зүүн барьцаа);* **барьцаанд барих** (данж болгон юм авах); **барьцаанд тавих** (данж болгон юм өгөх).

БАРЬЦААЛАХ 1. юмыг данж болгон авах; 2. барьцахын үйлдүүлэх хэв.

БАРЬЦААЛУУЛАХ 1. барьцаалахын үйлдүүлэх хэв; 2. барьцаалагдах.

БАРЬЦАЛДАХ 1. хүний харилцан барилцаж авах; 2. юмны авцалдан барилдах.

БАРЬЦАЛДУУЛАХ барьцалдахын үйлдүүлэх хэв.

БАРЬЦАХ хүний нэг нь нөгөөтэйгөө ямар нэгэн үйл явдалд адил жишээтэй байхыг эрмэлзэн бодож тэмцэх; *бие биетэйгээ барьцаж ажилд гарч өгөхгүй байжээ; бие өвчтэй хүнтэй барьцаж хэрхэн болох билээ.*

БАРЬЦАШ 1. лавтайяа, нэгэнт ийм боллоо, дүүрсэн хэрэг; 2. барагцаа, тойм.

БАРЬЦГҮЙ онолгүй, барьц муутай.

БАРЬЦТАЙ барьц сайтай, барихад тохиромжтой.

БАРЬЦУУЛАХ 1. барьцахын үйлдүүлэх хэв; 2. барьцаалагдах.

БАС 1. дахин, мөн адил, мөн; *өчигдөр бороо их л орсон, энэ өдөр бас оров; өглөө яваад бас явах буюу; чи бас харьсан уу?; бас адилхан; бас ингэж хэлжээ; бас л ирлээ;* 2. өөр; *бас хүн бий; бас бус олон зүйл;* 3. арай, арай ч, магад; *бас ч тийм биш; хэрэг болж бас ч мэднэ.*

БАСАГДАХ басахын үйлдэгдэх хэв.

БАСАМЖЛАГДАХ басамжлахын үйлдэгдэх хэв.

БАСАМЖЛАХ хялбар доройд үзэж доромжлох; дайрах, дээрэнгүйлэх; *намайг чадахгүй гэж басамжилж байна уу; тэгж болохгүй, дэндүү басамжилсан хэрэг болно.*

БАСАМЖЛУУЛАХ 1. басамжлахын үйлдүүлэх хэв; 2. басамжлагдах.

БАСАР: **басар цэцэг** ургамал олон настай ихэнхдээ хээр талд ургадаг, цэцэг ягаавтар, навч нарийн, өндөр нь 15—40 см. бий.

БАСАХ басамжлах, дээрэлхэх, доромжлох.

БАСГАХ 1. утаа уур зэргийн юм их л багсран гарах; *утаа басгах; уур басгах;* 2. адгах, тэвдэх.

БАСГУУЛАХ басгахын үйлдүүлэх хэв.

БАСУУЛАХ 1. басахын үйлдүүлэх хэв; 2. басагдах.

БАСХҮҮ юмны нэмэх дэндэх төлөвийг заана, бас гэсэнтэй ойролцоо; *басхүү олон бий.*

БАТ эвдрэхгүй, бөх; *бат суурьтай; бат тогтвортой;* **бат бөх, бат бэх** хорш.; *тэр сайхан ерөөл бат орших болтугай!* (ерөөлийн төгсгөлд хэлэх хариу); **бат илэрхийлэх** (ямар нэгэн байгууллагын гишүүн болохыг баталсан үнэмлэх); **бат од** (алтан гадас од); **бат цагаан** ургамал (модны нэр; гурав буюу таван хушуутай навчтай нягт судалтай, үр үндэс артай, үрийг цайны оронд ууж болно).

БАТАВТАР баахан бат мэт.

БАТАД хэзээд; *батад орших; батад итгэмжлэх.*

БАТАЛЬОН хэд хэдэн сумангаас бүрэлдсэн цэргийн анги; *барилгын батальон; танкийн батальон.*

БАТАТГАХ батдахын үйлдүүлэх хэв, бат болгох; *энэ сайн явдлаа улам бататгах хэрэгтэй.*

БАТГА арьсны сүвэнд тогтон буглаж гүвдрүү болох тосорхог зүйл; *нүүрэнд батга гарчээ.*

БАТГАНА амьтан нэг зүйл ялаа; **ялаа батгана** хорш.; *бадарч явсан газар балагтай батгана суусан газар өттэй* хууч..

БАТГАХ хөлс ихэд гарах; *хөлс батгах.*

БАТГУУЛАХ батгахын үйлдүүлэх хэв.

БАТДАХ хэтэрхий бат болох.

БАТЖИЛ бат бэх болсон байдал; *манай улсын хөгжил батжил.*

БАТЖИХ бат болох; *батжин бэхжих .*

БАТЖУУЛАХ батжихын үйлдүүлэх хэв.

БАТАЛГАА 1. батлах явдал, гэрч **баталгаа гаргах** (батлах бичиг бичих); **баталгааны газар** (гэрээ хэлэлцээрийг албан ёсоор гэрчлэн батлаж өгөх газар); 2. батлах бичиг; **баталгаатай захиа, захидал** (шуудангийн газраас тухайн эзэнд нь заавал хүргэн өгөхийг хариуцан авсан захиа).

БАТЛАГДАХ батлахын үйлдэгдэх хэв; *маргаангүй батлагдав.*

БАТЛАМЖ гэрээ хэлэлцээр зэргийг баталсан шийдвэр тогтоол.

БАТЛАХ 1. бат бэх болгох; **батлах бэхлэх** х о р ш . ; *батлан хамгаалах; батлан хамгаалах яам;* 2. ш и л ж с э н бүрмөсөн тогтох; *тогтоол батлах;* 3. үнэн болохыг зөвшөөрөх, нотлох; *батлах танхим; батлах хуудас; батлах бичиг.*

БАТЛУУЛАХ батлахын үйлдүүлэх хэв.

БАТНАХ дэмий ярих; *энэ юу гэж батнаж байна?.*

БАТНУУЛАХ батнахын үйлдүүлэх хэв.

БАТРАГА гахайн хоол.

БАТРАХ I гахай хоолоо идэх.

БАТРАХ II бат болох.

БАТРУУЛАХ батрахын үйлдүүлэх хэв.

БАТСАХ бат болох.

БАТТАХ улам бат болох; *манай төр улс улам баттасаар ирлээ.*

БАТХАН баахан бат.

БАТШИХ бат шинжтэй болох.

БАХ I 1. хав, сэтгэл дүүрэн хангамжтай; баясгалантай байдал; *хөөр бах болох; бахаа ханатал цэнгэх; манай тамирчид гарч ирэхэд бахтай байлаа;* 2. тав, бусдын мууд сэтгэл ханах байдал; *миний хожимдсонд бах чинь ханав уу гэж асуув.*

БАХ II 1. модны ур цулцан; *модны бах;* 2. модондоо нэвтэрч хатаж хатуурсан давирхайтай мод; *бахтай мод утаа тортог ихтэй.*

БАХ III мэлхий.

БАХАРДАЛ бачимдан давчдаж муужран унасан нь.

БАХАРДАХ бачимдан давчдаж муужран унах; *барилдсан бөх бахардан унав.*

БАХАРДУУЛАХ бахардахын үйлдүүлэх хэв.

БАХАРХАХ сэтгэлд хавтай бахтай, хангалуун болох, баясах; *бахархмаар сайхан дуулж байна; ийм сайхан хоттой болсондоо ард бид бахархаж байна.*

БАХАРХУУЛАХ бахархахын үйлдүүлэх хэв.

БАХГҮЙ үзэмж сонирхолгүй, сэтгэлд хангамжтай биш.

БАХДАЛ баяр хөөр, баясгалан; **баяр бахдал** х о р ш.. .

БАХДАЛТАЙ баярлаж сэтгэл хөгжиөөр.

БАХДАХ сэтгэл баясан хөөр бах болох; *баясгалантай хөөрхөн царайгий чинь бахдаад бахдаад ханашгүй дээ.*

БАХИМ богиновтор бөгөөд бөх чийрэг; *бахим биетэй; бахим хутга.*

БАХИМХАН баахан бахим.

БАХИР мөрөн голын дундын журам газар.

БАХИРАХ бархирах, чарлах орилох.

БАХЛУУР багалзуур.

БАХНА б и ч и г үүнээс зайлахгүй гэсэн утга; *тэгж бодсон бахна; ийм бахна.*

БАХУУ хоолой хавдах өвчин.

БАХУУТАХ бахуу өвчин тусах.

БАХЬ хавчих, чимхэх төмөрлөг багаж; *бахиар хавчих.*

БАЦАГ шажны ёсонд нэг хоногийн санваар (нэг хоног мах амсахгүй байх); **бацаг авах; бацаг барих** (нэг хоног мах идэхгүй байх).

БАЦАГЛАХ бацаг барих.

БАЦАС у р г а м а л хайлс модны адил дурстай нэгэн зүйл мод.

БАЧ заль, мэх.

БАЧИГНАХ их дуу чимээ үргэлжлэн гарах; *унгас савж байхад сабааны дуу тасралтгүй бачигнаж байв.*

БАЧИМ 1. түргэн, яаралтай, завдаагүй; *бачим хугацаа; бачим хэрэг;* 2. сандруу, тэвдүү; *бачим хүн.*

БАЧИМДАХ самгардах, сандрах, тэвдэх; *бачимдах хэрэггүй, бүү яар!.*

БАЧИМДУУ сандруу, тэвдүү, яаруу.

БАЧИМДУУЛАХ бачимдахын үйлдүүлэх хэв.

БАЧИТ бач заль ихтэй.

БАЧЛАХ бач заль гаргах; *аргат үнэг тэгж бачлав.*

БАЧЛУУЛАХ 1. бачлахын үйлдүүлэх хэв; 2 бачлагдах.

БАЧМАГ бачим; *бачимаг хүн.*

БАЧУУ 1. давчуу, бариу; *бачуу углуургатай; бачуу захтай дээл;* 2. ш и л ж с э н бачмаг, яаралтай; *бачуу хугацаа;* 3. тэвдүү, адгуу.

БАЧУУДАХ 1. цухал бариу болох; 2. ш и л ж с э н бачимдах, тулгарах.

БАЧУУДУУЛАХ бачуудахын үйлдүүлэх хэв.

БАЧУУХАН 1. баахан бачуу, яаруу; 2. давчуухан бариухан.

БАШГАНА у р г а м а л ойн аглаг болон нугад ургадаг нэг наст, цэцэгт ургамал, төрөл зүйл 100 шахам байдаг боловч нэг зүйл нь манай оронд ургадаг.

БАШИГ у р г а м а л өвсөн иштэй цэцэгт таван зүйл өнгө бий, хэлтэс дан ч бий, хэд хэдэн давхар ч бас бий.

БАШИЛДАХ I багших, багшралдах.

БАШИЛДАХ II адууг чөдөрлөж чөдрийн өмнөх хоёр алгыг тусгай богино гогцоогоор холбон бэхлэх; *морь башилдах.*

БАШИНГА а м ь т а н гол, мөрөн, тэнгэст амьдардаг, урт нь 20 орчим см. хүнд нь 150 грамм, авлаж ашигладаг нэг зүйл загас.

БАШИР I урхнаар залилах мэхлэх арга; **арга башир** х о р ш.; *башир гаргах.*

БАШИР II: **башир цэцэг** халуун үнэр амттай цэцэгтэй өвсөрхүү ургамал.

БАШИРЛАХ башир гаргах, бусдыг аргалан мэхэлж явах.

БАШИРЛУУЛАХ 1. баширлахын үйлдүүлэх хэв; 2. баширлагдах.

БАШИРТАЙ арга башир ихтэй.

БАШИРЧ башир гаргадаг хүн.

БАШИХ багших, өтгөрөх.

БАЯГЛАХ баярлах, баясах.

БАЯД I 1. Монголын нэгэн аймгийн нэр.

БАЯД II олон баян.

БАЯДАХ баян нь хэтрэх.

БАЯЖИХ юмаар баян болох; *телөөр баяждаг шөлөөр цаддаг* х у у ч.

БАЯЖУУЛАХ 1. баяжихын үйлдүүлэх хэв; 2. элбэг хүрэлцэхүйц болгох; *баримтаар баяжуулах.*

БАЯЛАГ 1. баян чинээлэг; *баялаг хүн; баялаг улс;* 2. юм их; *баялаг сүрэг; баялаг уурхай; баялаг ургац; баялаг хэл; үгсийн сангийн баялаг.*

БАЯН чинээлэг, юмтай; *баян хүн; баян тарган; эрхэм баян эрдэм, дунд баян өнөр, адаг баян адуу мал* х у у ч.; **баян жил** (юм хум элбэг дэлбэг жил); **баян түрүү** (малын алганаг орчны мах); **баян хангай** (а. газар дэлхий; б. чонын цээрлэсэн нэр); **баян хуур** (хөгжмийн зэвсэг).

БАЯР сэтгэлийн хөөрөл баясал, хөгжөөн; *баяр цэнгэл; баяр ёслол; баяр хөөр; баяр хүргэх; улсын баяр; хүүхдийн баяр; баярын бичиг; баярын утас; баярын хурал.*

БАЯРГҮЙ шуугиан хөгжөөнгүй, урамгүй.

БАЯРЛАЛАА баярласнаа мэдэгдэх үг; *би их баярлалаа!*

БАЯРЛАХ баяр төрөх баясах; *би баярлаж байна; та ч нэгэн адил баярлах болов уу.*

БАЯРЛУУЛАХ баярлахын үйлдүүлэх хэв. баярлахад хүргүүлэх.

БАЯРТ баяр бүхий; *баярт мэдээ авлаа;* **баярт мод** у р г а м а л (навч царсны адил болоод уртхан, дотор этгээд улбар шар, ноолуур мэт үстэй, үр бяцхан, модны их нь хэд хэдэн төвөр хүрдэг нэг зүйл мод); **баярт шаазгай** а м ь т а н (хушуу хар, жигүүр алаг, сүүл хар болоод үзүүрийн хоёр чандар цох цагаан, үүний салаалан ургасан нь шаазгайтай адил нэг зүйл шувуу).

БАЯРХАГ баярхуу зантай.

БАЯРХАХ баяндаа эрдэх.

БАЯРХУУ баярхамтгай.

БАЯСАЛЦАХ баясахын үйлдэлцэх хэв;

БАЯСАХ сэтгэл хөгжих; *даган баясах; баясах сэтгэл цээж дүүрэн.*

БАЯСГАЛАН баясахуй нь.

БАЯСГАЛАНТ баясгалан бүхий; **баясгалант хөөрөг** (амьддаа хийлгэсэн хөөрөг).

БАЯСГАХ баясахын үйлдүүлэх хэв; баясахад хүргүүлэх.

БАЯЧУУД олон баян.

БАЯЧУУЛ баячууд.

БЕНЗИН нүүрс ус төрөгчөөр бүрэлдсэн, өнгөгүй, хялбар уурсах, аягүй үнэртэй, хялбар ноцох шингэн бодис; гол төлөв нь нефтиэс буюу чулуун нүүрсний давирхайгаас гаргаж авна; дотоод шаталтын моторт түлш болгон хэрэглэнэ.

БЕНЗОЛ нүүрс төрөгч, чулуун нүүрсний давирхайгаас нэрж авна; өнгөгүй, шатах шингэн бодис; өөх, давирхай, каучукийг уусгана; будаг, тэсрэх дэлбэрэх бодис зэргийг үйлдвэрлэхэд хэрэглэнэ.

БЕНТОС гүн далайн ёроолын амьтад ба ургамлуудын ерөнхий нэр; бентосын зарим нь далайн ёроолд бэхлэгдэн орших ба зарим нь чөлөөтэйгөөр явж чадна.

БЕРИЛЛ берилли ба хөнгөн цагаан эслээр бүрэлдсэн шаравтар ногоон өнгөтэй эрдэнэ чулуу.

БЕРИЛЛИ болд шиг хөх саарал өнгөтэй, хатуу хөнгөн металл; янз бүрийн хиймэл металл хийхэд хэрэглэнэ.

БЕТОН цемент зэрэг барилдан зууралдаж нягтрах уусмалаар зуурсан, хайрга сайраар бүрэлдсэн холимог зүйл; хатсаны дараа маш хатуу чанартай болдог; барилгын үйлст хэрэглэнэ; *бетон гүүр; шахмал бетон.*

БИ нэгдүгээр биеийн төлөөний ганц тоо; *би таныг олон удаа харсан;* **юм бүхэнд би** гэх (биеэ хэтэрхий тоох).

БИАД: биад биад хийх нялх хүүхдийн гэнэт уйлах дуу.

БИВААЛИГ бийвийн адил болоод дүгрэгхэн иштэй, дөрвөн чихэнд нь чавхдас торгож хуурдах хөгжмийн зэвсэг.

БИВААН: биваан нугас амьтан нугасны төрлийн нэг зүйл.

БИВЛИН ургамал халуун чанарын ургамлын нэг зүйл үр, хэлбэр гонзгойлст урт, амт халуун бөгөөд эхүүн, эмнэлэг хоол хүнсний зүйлд хэрэглэдэг; **за бивлин** (бивлингийн нэгэн зүйл, монгол оронд ургадаг).

БИД (ЭН) нэгдүгээр биеийн төлөөний үгийн олон тоо; *бид ялна; бид хоёр; бид хэд; залуу уе бол бидний бахархал.*

БИДВАЛ ургамал янз сармисагтай адил, хэлтэсгүй амт амттайхан бөгөөд алмаган, жилд арван хоёр удаа ургана.

БИДНИЙХ бид гэдэг үгийн хамаадуулах хэлбэр; *энэ биднийх; биднийхийг аваачиж өгнө үү?*

БИДОН хавхаастай гонзгор сав; *сүүний бидон; 40 литрийн бидон.*

БИДРЭХ эрэх, хайх.

БИДҮҮ: бүдүү мод ургамал навч дөжир, навчин дээр нь юм зурж болно.

БИДҮҮЧ амьтан хоньтой адил бөгөөд хушуу богино, өнгө хар, маш соргог нэгэн зүйл гөрөөс.

БИДЭГЧ хэсэж тэнэгч.

БИДЭР 1. амьтны биеийн арьс үсэнд тогтсон өөр өнгийн бяцхан толбо буюу зурвас; *бидэртэй хул морь; хулан бидэртэй байдаг;* 2. жижигхэн зурвас толбо мэт болгон гаргасан хээ; **бидэр бялзуухай** амьтан (хушуу урт их аньсгын дээд талд нэг зурвас цагаан чандартай, биеийн чандар хар, цагаан холилдсон эрээн алаг шувуу).

БИДЭРЛЭГ: бидэрлэг мод ургамал Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хай Нан аралд ургадаг; судал нь барсын адил бидэртэй нэг зүйл мод.

БИДЭРЛЭХ юман дээр бидэр гаргах.

БИДЭХ олон газарт хэсүүчлэн тэнэж явах; *бидэн явагч бялзуухай.*

БИЕ хүн амьтны цогц эрхтэн, махбод; *бүх бие; хөвчин бие; биеэ угаах; биеэ хайрлахгүй;* ☆ **бие хөнгөжих** (нярайлах); **бие хөнгөрөх** (тамир тэнхээ сайжрах); **бие жирэмсэн** (хүүхэд олсон); **бие муу** (а. өвчтэй болох; б. **бие давхар** болох); **бие зүдрэх** (ядрах); **бие нялхрах** (тамир сулрах); **бие өвчлөх** (өвдөх); **бие сайн** (өвчингүй эрүүл); **бие сул** (тамир буурай, дорой биетэй); **бие тэгш** (тохиромжтой); **бие хүнд** (а. тамир муудаж сулрах; б. **жирэмсэн**); **бие чанга** (тамир тэнхээ сайтай); **бие эцэслэх** (нас барах, үхэх); **биед хүрэх** (насанд хүрэх); **бие зайлах** (буруулах); **бие боловсрох** (а. насанд хүрч бие, эрхтэн төгс боловсрох; б. цэцэг өвчнөөр өвдөж өнгөрөх); **бие шалтгаантай** (жирэмсэн); **бие дагшин** (биеийн хүндэтгэл); **бие засах** (өтгөн шингэн мөр үзэхийг зайлуулан хэлсэн үг); **бие засах газар** (өтгөн шингэн мөр үзэх газар); **миний бие** (би); *бие бие руугаа чихэх; бие биедээ захидал бичив; биеэр очиж уулзав;* **биеэ авч явах** (биеэ зөв сайн, цэвэр боловсон авч явах); **биедээ гомдох** (өөртөө гомдох); **биедээ найдах** (өөртөө найдах); **биеэ даах** (өөрөө өөртөө эзэн болох); **биедээ татах** (ямар нэг зүйлээр **өөртөө** ойртуулах); **биеэ тоох** (өөрийгөө ихэд бодох); **голын баруун бие** (голын баруун талд); **уулын ар бие** (уулын ар этгээд); **бие цогц** (бүтсэн байдал); **бие мөнгө** (бодит мөнгө); **биетэй тусламж** (үзэгдэхүйц тусламж); **бие бялдар** (хэв төрх); **бие давхар** (жирэмсэн);

бие махбод (биеийн цогц); **биеийн тамир** (бие махбодийг сайжруулахын тулд төрөл бүрийн дасгал хийх); **биеийн тамирч** (биеийн тамирыг эрхлэн хийх хүн); **биеийн амрыг харах** (үйл ажлын амар хялбарыг эрэх); **биеийн байцаал** (амьдралын үйл ажиллагааг бичсэн зүйл); **биеийн хүчин үнэлэх** (улс нийгмийн хэрэгт биеэр оролцон ажиллах); **биеийн хөдөлмөр** (биеэр гүйцэтгэх хөдөлмөр); **их бие** (аливаа юмны гол болсон хэсэг; *бүүны их бие; гэрийн их бие);* **биений юм** (эмэгтэйчүүдийн сарын тэмдэг); **бие хамгаалах** (биеэ арчлах); **бие хамгаалагч** (бусдын биеийг хамгаалагч); **гон бие** (цорын ганц); **бие бүтцийн зүй** (бие махбодийн байгуулал бүтцийн тухай ухаан, (анатоми); **биеийн гурван нүгэл** шашин (**амьтан** алах, хулгай хийх, буруу хурьцал).

БИЕГҮЙ 1. эзгүй, эзэнгүй, бодгүй, үзэгдэх баригдах юмгүй; 2. бие муутай болсон; *тэр ч өвд өвдсөөр байгаад биегүй болсон хүн.*

БИЕЖИХ 1. биетэй болох; 2. чийрэгжих.

БИЕЛГЭЭ монгол үндэстний бүжиг; *биелгээ хийх.*

БИЕЛҮҮЛЭХ 1. биелэхийн үйлдүүлэх хэв; 2. хийх, гүйцэтгэх; *даалгаврыг заавал биелүүлэх; биелүүлж чадахгүй үүрэг алга.*

БИЕЛЭГ I ургамал тал, нуга, ойн хаяа захад ургадаг нэг зүйл өвс; зарим газар туужууны өвс ч гэдэг.

БИЕЛЭГ II биерхүү, бие томтой; *биелэг шар.*

БИЕЛЭГДЭХ биелэхийн үйлдэгдэх хэв.

БИЕЛЭЛ аливаа юмны бүтэж биелсэн нь; *биеллээ олох.*

БИЕЛЭЛТ биелэхийн явц.

БИЕЛЭХ I бүтэх, гүйцэлдэх, боловсрох; *тэдний ажил биелэв; хүсэл нь биелжээ.*

БИЕЛЭХ II биелгээ хийх.

БИЕРХҮҮ 1. бие баахан том; 2. шилжсэн дээрэлхэн аашлах зан.

БИЕРХЭГ биерхүү.

БИЕТ бие бүхий; *биет бодис; биет юм.*

БИЕТЭЙ бие бүхий юм; *биетэй бодитой юм.*

БИЕЧЛЭХ биеэрээ хийх; *биечлэн шалгах; биечлэн удирдах.*

БИЕШИХ бие бий болохын шинжтэй болох.

БИЖ I сая төрсөн хүүхдэд төрсний дараа тохиолдох суулга өвчин.

БИЖ II нэгэн зүйл цагаан идээ.

БИЖИЙЛГЭХ бижийхийн үйлдүүлэх хэв.

БИЖИЙХ бижрэх, туурах; *нуруун дээгүүр нь юм бижийжээ.*

БИЖИРМЭГ бижрүү.

БИЖИРМЭГРЭХ бижирмэг болох.

БИЖРҮҮ 1. биенд туурсан жижигхэн гөвдрүү; *бижрүү туурах;* 2. юманд бий болсон мөхлөг; *айргийн бижрүү.*

БИЖРҮҮТҮҮЛЭХ бижрүүтэхийн үйлдүүлэх хэв.

БИЖРҮҮТЭХ 1. бижрүү туурах; *нүүр бижрүүтэх;* 2. юманд мөхлөг суух; бижирмэг тогтох.

БИЗ сул үг; *ти энэ өдөр хуралтайг мэдсэн биз; чи миний номыг үзээгүй биз?*

БИЙ байгаа, байна, буй; *ах гэртээ бий; аав ажил дээрээ бий.*

БИЙВ бишгүүр бялар зэрэг үлээдэг хөгжмийн зүйлд углаж үлээх зэгс хулсаар хийсэн хушуу.

БИЙВАА дөрөв буюу зургаан чавхдастай хөгжмийн зэвсэг.

БИЙЛЭГ элбэг чинээлэг.

БИЙЛЭГЖҮҮ элбэгжүү, чинээлэгжүү.

БИЙР үс хялгасыг багцлан ишинд суулгаж бичиг бичих, зураг зурахад зориулсан хэрэглэл; *бийрээр бичих; бийр нийлэх.*

БИЙРАА дүйнгэ, дорой, мулгуу, мохоо.

БИЛБҮҮР хуурамч худалч.

БИЛБҮҮРДЭХ чадамгай хууран хэлэлцэх.

БИЛБҮҮРЧ хууран хэлэлцэхэд чадамгай.

БИЛЕТ 1. ямар нэг үйл явдалд орж оролцохоор үнэ төлж авсан тасалбар хуудас; *киноны билет;* 2. урилгын хуудас; *урилгын билет.*

БИЛИГ I оюун ухаан төрөлхийн гарамгай, авьяас; *оюун билиг; ухаан билиг төгс;* ☆ **билгийн ташуур** (урьдын цагт ёслолд хэрэглэж байсан нэг зүйл ташуур).

БИЛИГ II: **билгийн улирал** сарны явдлыг баримталж цаг улирлыг тогтоох зүрхайн ёс, дорно зүгийн тооллын ёс нь сарны явдлыг гол болгох тул билгийн улирал гэнэ.

БИЛИГГҮЙ тэнэг, мунхаг, ухаангүй, ухаан муутай.

БИЛИГТ оюун билиг төгөлдөр; *оюун билигт авьяас төгөлдөр хүү;* **билигт гөрөөс** (хилэн гөрөөсний эм); **билигт өвс** у р г а м а л (угалз нь ургаагүй билигт далдуу); **билигт далдуу** у р г а м а л (гайхамшигт өвс; ишийн үзүүрт өнгөт угалз бий, өнгө элдэв зүйл гялбалзсан сайхан).

БИЛИГТЭЙ оюун билиг сайтай.

БИЛИНЧ 1. бэлэн үгтэй; 2. зулгуйч; 3. худалч.

БИЛҮҮ I хутга хайч зэргийг үрж ирлэх чулуу; *билүү гэсэн чулуу юу* (аман зохиол); *ширүүн билүү; зөөлөн билүү.*

БИЛҮҮ II мэдэхгүй зүйлийг хэлэлцэхэд хэрэглэх үг; *тэр жил чи очсон билүү?; явах билүү?; байх билүү.*

БИЛҮҮДЭХ билүүд үрж ирлэх; *хутга билүүдэх;* **хэлээ билүүдэх** (худал хэлэх, хов хэлэх).

БИЛЧИР уулзар нийлсэн газар; *голын билчир; замын билчир; Орхон Туулын билчирт нутагтай;* ☆ **чөдрийн билчир** (хаа, сумны уулзар).

БИЛЧИРЛЭХ 1. хоёр юмны хоорондоо уулзар нийлэх; 2. морь малыг аргамжих зэрэгт сур дээсийг салаалан уях.

БИЛЧЭЭР мал идэшлэх өвс бүхий газар; *малын билчээр; соргог билчээр.*

БИН I нэгэн зүйл боов, зуурсан гурилаар хайрч хийнэ; *далан давхар бин.*

БИН II: **бин битүү** 1. огт онгорхой нүх сүвгүй, бив битүү, цонхгүй; *бин битүү байшин;* 2. огт сэрэгдэх мэдэгдэх зүйлгүй, ажин түжин.

БИНАЙ ш а ш и н доод хөлгөний санваар сахигчдын дагаж мөрдөх цааз.

БИНГЭС цоохондой.

БИНДЭРЪЯА эрдэнийн чулуу; өнгө хөхөвтэрхөн бөгөөд маш тунгалаг, чанар хатуу гилгэр, чимгийн зүйлд хэрэглэнэ.

БИНЗИ у р г а м а л модонд ургадаг янз шаагуутай адил амт хүчтэй, үнэр сайн нэг зүйл жимс.

БИНТ I „0" тэмдэг; 1. тооны орныг эзлүүлэх хэмжигдэхүүн байхгүй гэсэн тэмдэг; 2. бичигт балласан зүйлийг тойруулан олон бинт тавивал дахин тэнхрүүл гэсэн болно; 3. хуучин бичигт олон юмыг дэс дараагаар тоочиход нэг бүрийн эхэнд ийм тэмдэг тавьдаг.

БИНТ II шарх, бэртэнгэ зэргийг боох боолт.

БИНТ III нягт чамбай суурьтай.

БИНТЛЭХ бинт I тавих.

БИНТОР: **бинтор цэцэг** у р г а м а л хэд хэдэн давхар туурын цэцэг; өнгө улаавтархан.

БИОЛОГИ амин судлал.

БИОЛОГИЧ амин судлалч.

БИОХИМИ амьд бодисын хувилах ухаан.

БИОХИМИЧ амьд бодисын хувилах ухааны.

БИРД 1. ш а ш и н гурван муу заяаны хоёрдугаар; хадарган чөтгөр ч гэнэ; 2. ш и л ж с э н маш харамч.

БИРДЛЭХ харамч зан гаргах.

БИРЖГЭР артаж иржгэр болсон, баржгар; **иржгэр биржгэр** х о р ш..

БИРЖИЙХ биржгэр болох.

БИРЧГЭР биржгэр; **ирчгэр бирчгэр** х о р ш..

БИРЧИГНЭХ олон жижигхэн юмны хөдлөх

БИРЧИЙЛГЭХ бирчийхийн үйлдүүлэх хэв.

БИРЧИЙХ бирчгэр болох.

БИТИЙ бүү тэг, битгий; *битий яв!; хожим битий тэгээрэй!.*

БИТГИЙ битий.

БИТҮҮ 1. задгай гэсний эсрэг утгатай үг; *ам амсаргүй битүү сав; битүү цагариг;* **битүү гудамж** (нэвт гардаггүй мухар); **битүү хавдах** (хавдсан газарт толгой шарх байхгүй); **битүү чихтэй** (чихээ цоолоогүй); **битүү хууз, битүү сахал** (эрүү шанаагаар үргэлж ургасан сахал); **битүү өвчих** (туламлан өвчих); 2. зай завсаргүй бүрхсэн нь; *битүү цас даржээ; гэрт битүү дэвсгэр дэвсэв;* ☆ **битүү хилэн** (нэгэн зүйл бараа); 3. ш и л ж с э н далд; **битүү утга** (далд утга); **битүү нүдээр харах** (сэмхэн ажиглах); 4. үйрэмлэг зүйлийн хэмжээ (хоёр гарын алганд багтах хэмжээ); *нэг битүү будаа.*

БИТҮҮДЭЭ далдуур; *битүүдээ чамайг хэлж байна.*

БИТҮҮЛЭГ I утга учир илэрхий бус; *битүүлэг утгатай; битүүлэг чанартай.*

БИТҮҮЛЭГ II сарны зурхайн 12-р сарын битүүний орой хуучин жилийг үдэж битүүлэхэд зориулсан мах идээ; **битүүлэг гүйлгэх** (нэг дор айлсаж байгаа айлууд харилцан бие биедээ мах өгөлцөн солилцох)

БИТҮҮЛЭГХЭН нилээд битүүлэг.

БИТҮҮЛЭХ 1. битүү болгох; *хашааны онгорхойг битүүлнэ; нүхний амыг битүүлэх;* 2. билигийн улирлын 12-р сарын битүүний оройн цаг, өнгөрөх жилийг үдэж, маргаашийн цагаан сарын шинийн нэгнийг угтах ёс гүйцэтгэх; 3. эд юмыг үзэлцэхгүй үнэ хэлэлцэхгүй харилцан солилцох; *үзгээ битүүлэх.*

БИТҮҮМЖ сав зэргийн ам амсрыг нээлгэхгүйн тул бэхлэн битүүмжилсэн нь; *битүүмжтэй бичиг; битүүмжтэй авдар.*

БИТҮҮМЖЛҮҮЛЭХ битүүмжлэхийн үйлдүүлэх хэв.

БИТҮҮМЖЛЭХ 1. сав зэргийн ам амсар, нүх сүвийг нээлгэхгүйн тул битүүлэн наах балацдах; *захидал битүүмжлэх;* 2. эд юм бүхий орон байшингийн үүд, авдар савны амсрыг хуулийн байгууллагаас лацдан нааж, нээж үл болох болгох; *хөрөнгийг битүүмжлэх.*

БИТҮҮН билигийн улирлын сар дутмын гучны өдөр; *зуны сүүл сарын битүүн.*

БИТҮҮРЭХ бөглөрөх, битүү болох; *цасанд дарагдан зам битүүрэв; зүүний сув бүтүүрсэн байв.*

БИЧ (ИН) амьтан 1. хөхөөр өсөх амьтан; хүнд маш ойр, бие туранхай, гар урт, гуя нарийн, олонхи нь урт сүүлтэй, дөрвөн мөчийн эрхий хуруу нь бусад хуруунаас тусгаар тул атгах авирахад сайн, хүнтэй адил шүдтэй, их бага ба өнгө адилгүй янз янз, дотроо зүйл ялгаал олон, дулаан оронд байдаг; 2. сарны зурхайн ёсны он тооллын арван хоёр эрхтний есдөхийн нэр; *бичин жил; бичин сар; бичин өдөр; бичин цаг.*

БИЧДЭС бичээс, бичигдсэн юм, бичсэн байдал.

БИЧИГ 1. авиа буюу дүрсийг тэмдэглэж бичих үсгийн систем; *орос бичиг; хуучин монгол бичиг;* **бичиг үсэг** хорш.; *манай улс бичиг үсэг үл мэдэх явдлыг үндсэнд нь устгажээ;* 2. албан газраас буюу хүний бичсэн зүйл; *албан бичиг; миний өвөрт нэг бичиг бий;* 3. утга зохиол; *бичиг зохиолд өгүүлсэн байдаг; хэл бичгийн тасаг;* **гунхаг бичиг** (засаг төрийн дээд байгууллагаас олон нийтэд зарлан тараах бичиг); **эх бичиг** (хуулбар биш, гарын үсэг, тамга бүхий бодит эх); **бичгийн хэрэглэл** (бичиг бичихэд хэрэглэх юм); **бичгийн цаас** (бичиг бичих цаас); **бичгийн хэл** (утга зохиолын хэл); **бичгийн зүү** (бичиг үдэх хадаас); **бичгийн дугтуй** (бичиг агуулах цаасан сав); **бичгийн сав** (бичиг агуулах түрийвч); **бичгийн хүн** (бичгийн ажилд мэрэгжсэн хүн); **бичгийн таарцаг** (бичгийн сав); **бичгийн машин** (бичиг цохиж бичдэг хэрэглэл).

БИЧИГГҮЙ бичиг үсэг мэдэхгүй, бичиг үсэг байхгүй; *бичиггүй хүн; зам явах бичиггүй; бичиггүй цаас.*

БИЧИГДЭЛ бичгээр бичигдсэн нь; *бичигдэл түүх; бичигдэл хууль.*

БИЧИГЛЭХ бичиг явуулах харилцах.

БИЧИГТЭЙ бичиг үсэг бүхий; *бичигтэй хад; бичигтэй хүн; бичигтэй яваа.*

БИЧИЛ бага, жижиг, бяцхан; **бичил бяцхан** хорш.; **бичил амин судлал** (бичил биетнийг судлах амин судлалын салбар ухаан); **бичил амь судлалч** (бичил амь судлалд мэрэгжсэн хүн); **бичил түрүү** (тарианы бяцхан түрүү).

БИЧИЛХЭН баахан бичил.

БИЧИЛЦЭХ 1. бичихийн үйлдэлцэх хэв; 2. харилцан бичиг солилцох; *захиа бичилцэх.*

БИЧИХ 1. бичиг үсгийг зуран тэмдэглэх; *захидал бичих; бичиг бичиж суув;* 2. зохиож найруулах; *зохиол бичих; роман бичих.*

БИЧМЭЛ гараар бичсэн; *бичмэл ном.*

БИЧҮҮЛЭХ бичихийн үйлдүүлэх хэв.

БИЧХЭН баахан бичилхэн.

БИЧЭЭС хад чулууны дээр бичсэн бичиг; *пайлуур дээрх бичээс.*

БИЧЭЭЧ 1. хуулан бичих ажлыг хийх албан тушаалтан; *машины бичээч;* 2. хуучирсан бичиг бичиж чадах хүн.

БИШ 1. бус, мөнтэй эсэргүүцэлдсэн үг; *миний ном энэ биш; мөн биш хоёрыг мэдэхгүй;* **өөх ч биш, булчирхай ч биш** зүйр (хоёрын хооронд); 2. өөр; *явахаас биш яах вэ; зөвхөн үншихаас биш, бичдэггүй;* 3. үйл ажил, ааш байдлаар бусдаас этгээд; *нэг л биш хүн дээ тэр чинь; хэлж байгаа үг нь биш л байна;* **биш үү** (а. бус уу; *чи дайралдсан биш үү?; өнөөдөр биш үү?;* б. шүү, лавшруулсан, бататгасан утгатай; *эцэг эхэд чинь хэлсэн биш үү; гэртээ харих нь зөв болох биш үү?*).

БИШГҮЙ олон, зөндөө; **бишгүй очсон** (олон удаа очсон); **бишгүй бий** (энд тэндгүй бий); *алдаа бишгүй байна.*

БИШГҮҮР 1. бийв зэргийг хэрэглэн үлээж дуугаргах хөгжмийн зэвсэг; *багласан бишгүүр; хөндлөн бишгүүр;* 2. лимбэ; *бялар бишгүүр* ☆ **бишгүүр өвс** ургамал (үет цагаантай адил болоод богино, уул хөдөө газарт ургана).

БИШГҮҮРДЭХ бишгүүр үлээн дуугаргах.

БИШГҮҮРДҮҮЛЭХ бишгүүрдэхийн үйлдүүлэх хэв.

БИШГҮҮРЧ бишгүүрдэхэд чадамгай хүн.

БИШИД бусад.

БИШИЛ бичил.

БИШРҮҮЛЭХ 1. бишрэхийн үйлдүүлэх хэв; 2. бишрэгдэх.

БИШРЭЛ 1. сүсэглэн дуршаах сэтгэл; *сүсэг бишрэл; ач тусыг санан бишрэл төрөв.*

БИШРЭНГҮЙ бишрэлтэй.

БИШРЭХ 1. сүсэглэн дуршаах сэтгэл төрөх; 2. хүндэтгэн итгэмжлэх болох; *амийг аварсан мэс засалчийг хараад дотроо бишрдэг байжээ.*

БИШҮҮРХҮҮ танихгүй, дасаагүй хүнээс бэрхшээмтгий, ичиж зайлсхийх байдал; *бишүүрхүү хүүхэд.*

БИШҮҮРХҮҮЛЭХ бишүүрхэхийн үйлдүүлэх хэв.

БИШҮҮРХЭГ бишүүрхүү.

БИШҮҮРХЭХ бишүүрхэг зан байдал гаргах.

БЛОК I эвсэл.

БЛОК II дугуйт өргүүл.

БОВ: бов бор маш бор.

БОВОРХОН хөхөвтөрхөн өнгө.

БОВЬ тэнэг, мангуу.

БОГ I бага жижиг мал (хонь ямаа); *бог малын тэжээл; бог малын хээлтэх үе.*

БОГ II 1. салхинд хуралдан бөөгнөрсөн унаги өвс; *бог өвс;* 2. усанд хөвж хуралдсан хаягдал хог; *бог хөг;* 3. хурга тугалын гэр, хальс буюу хаг; 4. нүдэнд унасан цагаа ба нүдэнд унасан хог саг; *нүдэнд бог унах; бог орох; нүдэнд орсон бог, шүдэнд орсон мах* з үйр.

БОГД олны дотроос цэцэн гэгээн, эрдмээр бүсдаас хэтийдсэн хүнд олгох цол.

БОГДГО: богдго богдго хийх богдгор юмны үргэлжлэн хөдлөх.

БОГДГОНОХ богдгор юмны богдго богдго хөдлөх байдал.

БОГДГОР хэтэрхий тагдгар, атигай.

БОГДОЙХ богдгор болох.

БОГДОЛЗОХ богдгор юмны богтос богтос хөдлөх байдал.

БОГДОС: богдос богдос хийх богдгор юмны байн байн хөдлөх.

БОГДОХ: богдох шүүр, хулс бургасны найлзуураар хийсэн хог арилгах шүүр.

БОГЗЛОХ ямар нэгэн уяа мэтийн юм гэнэт алдрах, тайлагдах.

БОГИНО 1. уртын эсрэг утга, охор, уртгүй; *богино оосор; богино унь;* **богино хавирга** (өвчүүний дээд этгээдийн охор хавирга); **богино долгион** (10—150 метр радио долгион); 2. өндөр биш намхан; *богино нуруутай;* 3. удаан биш; *богино хугацаа; богино өвөл;* 4. ш и л ж с э н гүн гүнзгий биш; *богино санаа;* 5. их биш хэмжээний, багашиг; *богино яриа; богино жүжиг;* ☆ **гар богино** (ядуу дутуу; *гар богино, ганзага татуу).*

БОГИНОВТОР нилээд богино.

БОГИНОДОХ хэтэрхий богино болох; *энэ дээл богиноджээ.*

БОГИНОДУУЛАХ богинодохын үйлдүүлэх хэв.

БОГИНОСГОХ богиносохын үйлдүүлэх хэв.

БОГИНОСОХ улам богино болох; *өдөр богиносч явна.*

БОГИНОТГОХ богинотохын үйлдүүлэх хэв.

БОГИНОТОХ улам богино болох.

БОГИНОХОН баахан богино.

БОГОЛЗУУР багалзуур.

БОГОЛЗУУРДАХ багалзуурдах.

БОГОЛШИХ гурил зэргийн юм хөгцрөн ваалах.

БОГООС гүүний урд хөлөнд богочийг зүүхэд хөлийг бохируулахын тул зандрах аялга.

БОГОЧ I морь малын урд хөлийг бохирдуулан торгох сур дээс.

БОГОЧ II уулын бяцхан онь хөтөл.

БОГОЧЛОХ морь малын урд нэгэн хөлийг бохируулан богоч зүүх; *гүүг саахдаа богочлов.*

БОГОЧЛУУЛАХ 1. богочлохын үйлдүүлэх хэв; 2. богочлогдох.

БОГСОР: богсор нохой маш богино хушуутай нохой.

БОГТ I: **богт чөмөг,** богтос.

БОГТ II х у у ч и р с а н хэлэлцэж эр эм бололцоход эрийн талаас хүүхний талд өгөхөөр амласан юм; *сүй богт.*

БОГТЛОХ х у у ч и р с а н хоёр этгээд хэлэлцэн тогтсон ёсоор эр эм бололцон гэрлэх ёслол хийх; *богтолж авсан гэргий нь байв.*

БОГТЛУУЛАХ 1. богтлохын үйлдүүлэх хэв; 2. богтлогдох.

БОГТОЙХ сэтгэл зовниж ганцаараа гиюурэн суух.

БОГТОС малын шилбэ бугалаг хоёрын хоорондох чөмөг яс.

БОГЦ юм агуулж эмээл дээгүүр тэгнэхэд зориулан хийсэн авсаархан сав.

БОГЦЛОХ богцонд юм агуулах.

БОГШИРГО а м ь т а н болжмор шувууны багийн нэг зүйл өвөггүй, жиргэдэг шувуу.

БОГШИХ I борших, хандших; *цай богших; богисон шөл.*

БОГШИХ II ажил явдалд бие зүдэж хөндүүр мэт болох; *бие богших.*

БОГШИХ III хогших, хөрөнгөтэй болох.

БОГШООДОЙ а м ь т а н бялзуухайн нам богширготой төстэй нэг зүйл жижигхэн шувуу; *эргийн бор богшоодой.*

БОД 1. том мал, адуу тэмээ үхэр гурав бод малд тооцогдоно; 2. шатрын ноён ба хүүгээс бусад дүрсүүд; 3. малыг үнэ таацуулан бодох нэгж (тэмээг 1,5—2 бод, адуу үхэр хоёр тус тус нижгээд бод; 5—7 хонь, 7—10 ямааг тус тус нижгээд бод гэнэ).

БОД II бодис юм; *бие бод.*

БОДВОЛ санавал; *би бодвол явсан нь зохистой.*

БОДГАЛИС ш а ш и н Бурхан болон бусад хамаг амьтан.

БОДГАЛЬ ш а ш и н амь, санаа бүхий.

БОДГҮЙ 1. биегүй; *бие бодгүй;* 2. үнэнд бүтсэн биш; 3. хуурамч; *бодгүй хэрэг.*

БОДИЗ у р г а м а л модны үр; нэг боргоцотт 108 ширхэг үр байдаг гэдэг, үүгээр эрэх хийнэ, *бодиз эрэх.*

БОДИС 1. хүний ухамсраас хамаардаггүй түүний гадна байдаг бодитой зүйл; 2. биетэй юмны бүтсэн эд; *бодисын бүтэц; тэсрэх бодис;* **бодис зүй** (физик); *бодисын солилцоо; түмэн бодис.*

БОДИСАД буддын шашны ёсны бодь сэтгэлийг олсон амьтан.

БОДИТ бие бүхий юм; **бодит бараа** (овор адил буюу чанар адил юм); **бодит цалин** (цалингаар худалдан авах чадвар).

БОДЛОГО 1. бодол; *бодлого болон зогсож* байв; 2. тоо бодлогын бодож гаргах даалгавар; *бодлого бодох;* ☆ **тоо бодлого** (тооны энгийн чанар үйлдлийг судлах тооны ухааны нэг салбар, арифметик).

БОДЛОГОГҮЙ санаа бодолгүй, болгоомжгүй, иш үндэсгүй, суурьгүй; *чи яасан бодлогогүй хүн бэ?; бодлогогүй бол боол болно.*

БОДЛОГОТОЙ иш үндэстэй, буурь суурьтай, болгоомж сайтай.

БОДЛОХ бод болгох, малыг бод болгон таацуулан бодох.

БОДЛУУЛАХ бодлохын үйлдүүлэх хэв.

БОДМОГЛОХ 1. хааш яаш буюу хуумгай бодох; 2. хүний ганцаар ярих.

БОДОГДОХ бодохын үйлдэгдэх хэв; бодолд орох; *надад ингэж бодогдов.*

БОДОЛ хүний ухаандаа сэтгэх, эрэгцүүлэх: **санаа бодол** х о р ш.; **бодол болох** (гүнээ бодох); **бодол гаргах; бодол тавих** (чармайх, улайх); **бодолтой байх** (болгоомжтой, сэргэлэн байх).

БОДОЛГҮЙ санах сэтгэхдээ муу, хөнгөн хүумгай, юмыг боддоггүй, болгоомжгүй.

БОДОЛТОЙ их юм боддог, бодол ихтэй, бодмоор, болгоомжтой.

БОДОЛХИЙЛЭХ бодлого болох, санаашран бодох.

БОДОЛЦОХ 1. ямар нэг зүйлийг тус тустаа бодох; 2. олон зүйлийг хамруулан бодох.

БОДОН зэрлэг гахайн эрэгчин; **бодонгийн сур** (бодон гахайн арьс); **бодонгийн халх** (бодонгийн биеийн саарь).

БОДОО их зэрэг сувилах өвчин, цэцэг өвчин.

БОДОХ 1. сэтгэх эрэгцүүлэн хянах, санах; *бодож бодож ингэж хэлэв; дотроо бодох; бодвол арга олдоно; бодоод бодоод бодын шийр дөрвөв з үй р;* 2. тоог олж гаргах; *даалгаврыг бодох; сампингаар бодох;* ☆ **бодох мөхлөг** (сампин).

БОДРОЛ: бодрол бичиг 1. ямар нэгэн ухааныг тайлбарлах мэдрүүлэх зохиол; 2. х у у ч и р с а н хаан эзэнд мэдүүлэх айлтгал бичиг.

БОДТОЙ 1. бие махбодтой, биетэй; *бодтой байдал;* 2. чихам, жинхэнэ; *бодтой бараг;* **бодтой сувд** (жинхэнэ сувд).

БОДУУЛАХ бодохын үйлдүүлэх хэв; *тоо бодуулах; данс бодуулах.*

БОДЬ хар хоргүй, амарлингуй; *бодь сэтгэл; бодь хүн;* ☆ **бод гөрөөс** а м ь т а н (янз гахайтай адилхан, хамартаа эвэртэй нэгэн зүйл амьтан).

БОДЬТОЙ бодит.

БОЖМОГ у р г а м а л өндөр нь 20—40 см., мөчир салаа улаавтар өнгөтэй, навч нь хос буюу гурваар байдаг, цөл, заримдаг цөл бүсэнд ихэнхдээ ургадаг, хоёр наст ургамал.

БОЖРОГО а м ь т а н болжмор шувууны баг, нэг зүйл жижиг шувуу.

БОЗ I 1. цагаан идээ, айргийн тостой бүцалгасан цагаа; 2. хонь малын өвчүүний хормойн арьс махыг хамтаар авч, арьсаар махыг хучиж ороогоод үсийг зумалж чанан болгосон хоол; 3. бозлогийн хорхог.

БОЗ II: **боз чавга** у р г а м а л навч нь зулгардаггүй том модонд ургадаг, хоёр хуруу хиртэй том чавга.

БОЗГО шувууны сөдний дараа ургасан өрөвлөг.

БОЗЛОГ I: **бозлог гургуул** а м ь т а н монгол Алтайн орчимд оршдог нэг зүйл гургуул шувуу.

БОЗЛОГ II а м ь т а н нэгэн зүйлийн мэрэгчин, хэлбэр мөндөл мэт, өнгө шаравтар, махыг иддэг.

БОЙ 1. сувилал, арчилгаа; *бой нь арилаагүи, борви нь тэнийгээгүй хүүхэд;* 2. бохир хатуу ажил; *би тэдний бойг бойлж байна.*

БОЙВ х у у ч и р с а н хүндэтгэх хүний хөл ба гутал; бойвог ч гэнэ.

БОЙГО бойнго, дүйнгэ.

БОЙДОНГО бойнго, бойдоо.

БОЙДОО I бүдүүлэг.

БОЙДОО II х у у ч и р с а н ноёдын аж ахуйн хэргийг эрхлэх даамал.

БОЙЖИЛТ өсөлт, торнилт; *хүүхдийн бойжилт; төл малын бойжилт.*

БОЙЖИХ 1. өсч торних; *бойжих нас; хүүхэд бойжих газар;* 2. баахан дэвжих, өөдлөх; *бойжиж яваа айл.*

БОЙЖЛОГО бойжиж байгаа нь.

БОЙЖУУЛАХ бойжихын үйлдүүлэх хэв.

БОЙЛОХ 1. сувилах, арчлах; *өвчтөнийг бойлох;* **бойлох тойлох** х о р ш.; 2. хүнд хүчир ажил хийх; *бойг нь бойлох.*

БОЙНГО болхи, бүдүүн.

БОЙПОР үнэртэн шатаах сав.

БОЙР I уулын бөөрөг газар.

БОЙР II эр халиу.

БОЙРЛОХ бойр газраар явах.

БОЙТОГ I бугын ясан эвэр унаж цусан эвэр ургахаар цухуйж эхэлсэн нь.

БОЙТОГ II 1. хүйтэн цагт гутлын гадуур давхарлан өмсөх дэгтий; 2. нялх хүүхдийн өмсөх жижигхэн гутал; 3. хөл нь өвчтэй хүний өмсөх зөөлөн юмаар хийсэн гутал.

БОЙШИЛ хув.

БОКС нудрага, тусгай зориулан хийсэн бээлий өмсч, зохих дүрэм ёсоор зодолдох спортын нэг зүйл; *боксын тэмцээн.*

БОКСЧ боксын мэрэгжил эрхэлсэн биеийн тамирчин хүн.

БОЛ 1. болох гэдэг үйл үгийн захирах тушаах хэлбэр; *чи сургуулийн захирал бол!; чи малчин бол!;* 2. аваас, болбаас, болбол; *Дорж бол багш; арслан бол араатан; чи явах бол яв!; ажил хийх л бол дуустал хий;* 3. бай, гэсэн, болов; *дөрөө урт ч бол газарт хүрэхгүй; дүү сайн ч бол ахад хүрэхгүй; чи дуртай ч бол дургүй ч бол чамд тушааж байна би.*

БОЛБОЛ 1. бол гэдэг холбоос; 2. чадвал, арга нь олдвол; *болбол түүнийг олж авъя; болбол сайн ажиллахыг бодно.*

БОЛГОН 1. болгох; *бөх болгон хадах; цэвэр болгон засамжлах;* 2. дутам, бүр бүхэн: *өдөр болгон; хүн болгон адилгүй, хүлэг болгон жороогүй* з ү й р.

БОЛГООМЖ хичээнгүйлэн хянах сэрэмж; *болгоомжтой байгаарай!; болгоомж муугаас болох.*

БОЛГООМЖГҮЙ болгоомж муутай, хянамжгүй, сэрэмж муу.

БОЛГООМЖЛОЛ болгоомжлох үйлийн нэр.

БОЛГООМЖЛОХ хичээнгүйлэн хянаж сэрэмжлэх; *хотын гудамжийг хөндлөн гарахдаа автомобиль, автобус зэрэг олон зүйлийн машинаас болгоомжилбол зохино; алхам бухэндээ болгоомжлох хэрэгтэй.*

БОЛГООМЖЛУУЛАХ болгоомжлохын үйлдүүлэх хэв.

БОЛГООМЖТОЙ болгоомж сайтай, хянамгай.

БОЛГООХ 1. болгоомжлох; 2. хүний өвчний байдал ямар байгаа тухай зориуд асуун үзэх эргэх; 3. хүндэтгэвэл зохих хүний харах, үзэх, ажиглах, хянах; *та энэ бичгийг болгоож хайрлана уу.*

БОЛГОХ 1. болохын үйлдүүлэх хэв; *Гомбыг ойн ангийн дарга болгов;* 2. боловсруулах, чанах; *цай болгов; идээ болгов; ном болгох; цаас болгох;* 3. хүлээх, хойшлуулах; *үд болгов; өглөө болгов.*

БОЛД зохих хэмжээний нүүрстөрөгчтэй нийлүүлсэн төмөр, чанар нь маш хатуу; *болд сэлэм.*

БОЛДОГ дов, гүвээ; *болдог толгой дээр гарав.*

БОЛЖМОР а м ь т а н жиргэдэг жижиг шувууны ерөнхий нэр; **болжмор бялзуухай** а м ь т а н (хятруу бялзуухайн нам, өнгө үнсэн хөх, харавтархан бидэр бий, тариа түүж иднэ).

БОЛЗОЛ 1. болзоо; *ахуй болзол;* 2. шаардлага; *хөдөлмөрийн баатрын цол авах болзлыг хангав.*

БОЛЗОО 1. урьдаас тогтоосон хоног хугацаа; *болзоо болзох; болзоо тогтоох; болзоондоо ирэх; тав хоногийн болзоо тогтоов;* 2. урьдаас хэлэлцэн тогтоосон газар; *болзоот газар; болзоотын бор толгой дээр уулзав* үлгэр.

БОЛЗООГҮЙ 1. магадлашгүй, магадгүй; 2. итгэшгүй, итгэлгүй; 3. болчимгүй.

БОЛЗООЛОХ болзоо тогтоох.

БОЛЗООТОЙ болзоо бүхий; *болзоотой цаг; болзоотой хоногтоо багтахгүй ажил билээ.*

БОЛЗОР болзол.

БОЛЗОХ болзоо тогтоон шийдвэрлэх; *хэдэн хоногийн дараа уулзана гэж болзжээ; хоног болзох хэрэггүй.*

БОЛЗОШГҮЙ магадгүй; *болзошгүй хэрэг; энэ өдөр багш ирж болзошгүй.*

БОЛЗУУЛАХ болзохын үйлдүүлэх хэв, болзоолох.

БОЛИУЛАХ болихын үйлдүүлэх хэв.

БОЛИХ зогсох, сулрах, дордох, доройтох; *чи наадахаа боль!; тамхи татахаа болих хэрэгтэй; цас орохоо болив; хавсрага тавихаа болих нь байна; тэр ном үзэхээ болио юу?; хоолой нь бүр болио шив дээ.*

БОЛМООР болох төлөвтэй; *идэж болмоор хоол байна; уншиж болмоор бичиг байна.*

БОЛОВСОН эрдэм соёлтой, боловсролтой, үзэмжтэй, үзэсгэлэнтэй; *боловсон үйлчлэх; хотыг боловсон тохилог байлгах хэрэгтэй; боловсон байдал;* ☆ **боловсон хүчин** (үйл ажиллагаа үйлдвэрлэлийн аль нэгэн салаа мөчрийн ажилтны бүрэлдэхүүн; *техникийн боловсон хүчин);* **боловсон хүчний хэлтэс** (боловсон хүчнийг удирдан, ажил албанд хувиарлаж тохоон томилох хэлтэс).

БОЛОВСРОГДОХ боловсрохын үйлдэгдэх хэв.

БОЛОВСРОЛ боловсрох үйлийн нэр; **соёл боловсрол** х о р ш.; *дээд боловсролын сургууль; дунд боловсролтой.*

БОЛОВСРОНГҮЙ боловсорсон, эрдэм соёлтой; *боловсронгуй улс; боловсронгуй хүн.*

БОЛОВСРОХ 1. дутуу ба түүхий биш болох; *намар цагт жимс боловсров;* 2. үйл ажлын үр хариу бүтэх гарах; 3. эрдэм номыг сурч судлах; *сурч боловсрох;* ☆ **бие боловсрох** (а. хүний төлжиж боловсрох; б. цэцэг өвчнөөр өвдөж боловсрох).

БОЛОВСРУУЛАХ 1. боловсрохын үйлдүүлэх хэв; 2. юмыг нягтлан хянаж бодох; төлөвлөх; *илтгэлийн сэдвийг боловсруулах; хэргийг боловсруулах; биеэ боловсруулах.*

БОЛОВ УУ 1. асуух үг; *мэдэх болов уу?; очсон болов уу?;* 2. гуйх чанартай үг; *эрхбиш хүрэлцэн ирэх болов уу.*

БОЛОВЧ бол гэдэг үйлийн зэрэгцэх хэлбэр; авч, ч; **хичнээн боловч** (хичнээн авч); **хэдий тийм боловч** (хэдий тийм авч); **хэзээ боловч** (хэзээ ч); **хэн боловч** (хэн ч).

БОЛОЛТОЙ магадгүй, төлөвтэй; *өнөөдөр номын дэлгүүрт сонин ном ирэх бололтой; онгоц нисэх бололтой; тэнгэр цэлмэх бололтой.*

БОЛОЛЦОО боломж, нөхцөл; **арга бололцоо** х о р ш.

БОЛОЛЦООГҮЙ аргагүй, нөхцөлгүй, боломжгүй.

БОЛОЛЦООТОЙ арга бүхий, боломжтой, нөхцөлтэй.

БОЛОМЖ бололцоо, нөхцөл, арга; **арга боломж; нөхцөл боломж** х о р ш.

БОЛОМЖГҮЙ арга бололцоогүй, нөхцөл бололцоо байхгүй.

БОЛОМЖТОЙ арга бүхий, бололцоотой, **нөхцөлтэй.** ᠪᠣᠯᠣᠮᠵᠢᠲᠣᠢ

БОЛООСОЙ болохын мөрөөдөн хүсэх хэлбэр; *бие нь түргэн эдгэрэх болоосой.* ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠢ

БОЛОР техник, гоёл чимэглэлийн зүйлд хэрэглэдэг чулуу; төрөл зүйл олон, хувийн жин 2,65, хатуугийн зэрэг 7; **усан болор** (тунгалаг, гонзгойвтор, талстай чулуу); **утаат болор** (утаа тунасан мэт өнгөтэй нэг зүйл болор); **даралттай болор** (радио техникт хэрэглэдэг нэг зүйл болор); ☆ **болор бие** (нүдний дотор байдаг тунгалаг бие). ᠪᠣᠯᠣᠭ

БОЛОХ бол гэдэг үйлт нэрийн ирээдүй цагийн хэлбэр; *болох байх; болох юм; болох боловч; болох биз; болох болов уу?; болох ёстой; болох ажээ; болох болжээ; болохын аргагүй; болохы нь үзье; болохтой хэрэг; болохоор барахгүй; болохоос биш яах вэ;* **болох уу?** (зөвшөөрөл гуйх); **болох зохих** (таарах, таацах, тохирох, зохицох, бололцох, зохисыг үзэж); **болох болохгүй** (таарах таарахгүй, тохирох тохирохгүй, нийцэх нийцэхгүй; *болох болохгүй хүний үгэнд бүү ор, болсон идээнээс бүү зайл!; болох болохгүйг бүү мэд);* 1. ямар нэг юмны байдал хувирах; **улс болох** (тусгаар тогтносон улс байгуулах); **мөс болох** (мөсрөх); **боос болох** (хээл олох); **чулуу болох** (чулуурах); **хир болох** (буртаг тоос сууж хиртэх); **хир болох** (туйлдан цөхөх); **мах болох** (туйлдан ядрах); **хар болох** (а. юмны өнгө харлах; б. лам дүрмээ өөрчлөх); **мохоо болох** (хурц байдал алдрах); **тулам болох** (а. тулам шинж орох; *мөнгөний махан тулам болох; өрийн тулам болох;* б. тулманд чихсэн юм шиг байдал орох; *тулам болтлоо хавдах);* **муу болох** (муудах); **сайн болох** (сайдах, сайжрах); **эрүүл болох** (эрүүлжих); **хэнхэг болох** (хэтэрхий дурлах); **хэвшил болох** (дадах, занших); **үгүй болох** (алга болох); **алга болох** (үзэгдэхгүй, олдохгүйд хүрэх); 2. ямар нэг үйл эзэмших; **багш болох** (багшийн үүрэг хүлээх); **архичин болох** (архинд орох); **эмч болох** (эмчийн мэрэгшил эзэмших); **тогооч болох** (тогоочийн мэрэгшил эзэмших); **анчин болох** (авлах мэрэгшилтэй болох); **сайд болох** (сайдын тушаал хүлээх); **хулгайч болох** (хулгай хийх); **бөө болох** (бөөгийн шүтлэг эрхлэх); 3. ямар нэг юмд нийлэх, хамтрах, холбогдох; **гал болох** (а. айл гэр болох; б. аяны хүний нэгэн оромжинд гал нэгдэх); **гэр бүл болох, айл гэр болох** (эр эм бололцох, өрх гэр тусгаарлах); **ураг болох** (а. эр эм болох; б. ургийн холбоо сүлбээ бүхий; *тэр бол миний ураг болох хүн);* **эхнэр болох** (а. хуучирсан эхнэр үс хувцас хэрэглэх; б. нөхөрт холбох); **бараа болох** (хань болон дагалдах); **хань болох** (а. хань бараа болж явах; б. нөхөр хань болох); **түшиг болох, тулгуур болох** (дэмжлэг үзүүлэх); **гол болох** (зонхилох, голлох); 4. ямар нэг юманд уршиг нөлөө учруулах; **өр болох** (өрөнд орох); **гарз болох, хохирол болох** (ашиг жавшаан алдах); **нүгэл болох, хилэнц болох** (гэм бурууд хүрэх); **тээр болох** (тээр дараа учруулах); **саад болох** (тотгор учруулах); **гай болох** (гай зэтгэр учруулах); **хөө болох** (гай болох); **гэм болох** (гэм учруулах); **хал болох** (хал учруулах); **шорвог болох** (шорвогдох); 5. нэмэр тус хүргэх, үзүүлэх; **ашиг болох** (нэмэр жавшаан хүртэх); **зууш болох** (а. бусдад элэглэгдэн хэлцэгдэх; б. бусдын эрхшээлд автагдан ашиглагдах); **идэш болох** (бусдын эрхшээлд орох); **нүд болох** (нүдний оронд хэрэглэгдэх); **гар хөл болох** (хамсаа тус хүргэх); **хэрэг болох** (а. хэрэглэгдэх; б. хэрэг үүдэх); **хэл болох** (хэл мэдээ залгуулах); 6. цаг улирлын ээлжлэн солилцох; **цаг болох** (хугацаа тулгамдах); **өн болох** (цагийн улирал ган зудгүй зохистой байх); **зуд болох** (цас ихэд орох буюу цасгүйгээр харын хүйтэн болох); **удаан болох** (удах); **халуун болох** (халуун ихсэх); **харанхуй болох** (гэгээ гэрэл тасрах); **шөнө болох** (харанхуй болох); **өглөө болох** (өдөр болж эхлэх); **зун болох** (зуны байдал орох); 7. ямар нэгэн хөл хөгжөөнтэй үйл явдал тохиох; **баяр болох** (баяр цэнгэл үйлдэх); **хөл болох** (а. хөөрөн хөгжих; б. хөл хөдөлгөөн ихсэх); **ёслол болох** (ёслол хийх); **сүйд болох** (а. сэтгэл ихэд хөгжих; б. сүйрэх, сүйдэх); **сүр болох** (сүр гаргах); **дажин болох** (үймэх, самуурах); **хэрүүл болох** (хэрэлдэх); 8. ямар нэг юм хувиран эхлэх; **танил болох** (танилцах); **эр болох** (*өсч эрийн цээнд хүрэх*); **хүн болох** (а. өсч бойжих; б. хүний зан чанар илрэх; *хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа);* **дургүй болох** (дургүй хүрэх); 9. хүчинд автагдах буюу үл тоомсорлох байдлыг илэрхийлэх санаа; *идэхчээ болох; хийхчээ болох; бичихчээ болох; унтахчаа болох; явахчаа болох;* **хийсэн болох** (хийж байгаа байдал үзүүлэх); **идсэн болох** (идэж байгаа байдал үзүүлэх); **үзсэн болох** (үзэж *байгаа байдал* үзүүлэх); 10. өөртөө ямар нэг юм эзлэх, эзэмших; **талтай болох** (танилтай болох); **нүүртэй болох** (дотночлон дэмжигчидтэй болох); **их зантай болох** (их зан үзүүлэх, их зан гаргах); **хоолтой болох** (хоолоо олж идэх чадвар олох); **дуртай болох** (дур орох); **сэтгэлтэй болох** (янаг хайртай болох); **өвчтэй болох** (өвдөх); 11. бусдын эрхшээлд автагдах; *боол болох; зарц болох; хамжлага болох;* 12. ямар нэг юм боловсрох; *жимс болох; цай болох;*

цэцэгт болох; өвчинд болох; **хоол болох** (а. хоол боловсрох; б. сайн шингэх; *өнөөдрийн идсэн мах надад хоол болжээ;* в. бусдын зууш болох); 13. нэг юмнаас нөгөө юм үүдэх; *дайсан болох; капитализмын дээд шат болох империализм; садан болох нэг хүн; өвөг болох дээд үе; Туулын голын эх болох газар;* 14. ямар нэг юм хүсэн ихэд санаашрах, мөрөөдөх; *санаат болох; өвчин болох; хүслэн болох;* 15. олон юмны дотроос оройлон ялгарах; *сор болох; сод болох; магнай нь болох; аврага болох; туг болох;* 16. ямар нэгэн үйл явдлын сэжиг сэдэв цухалзах; *жиг болох; энэ хоёр нэг учир болжээ;* 17. ямар нэг шалтгаанаас санаа сэтгэл алгасах; *ярандаа болох; ярьсандаа болох; уурласандаа болох; ичсэндээ болох;* 18. ямар нэг үйл явдал ирэх, эхлэх, *зовох болох; мэдэх болох; хийх болох; үзэх болох; унших болох;* 19. болохуйц, болмоор; *санаж болох; уншиж болох; бичиж болох; сурч болох; идэж болох; хэлж болох.* ᠪᠣᠯᠤᠬᠤ

БОЛОХГҮЙ 1. бүтэхгүй; *бүтэж болохгүй ажил юм; болохгүй болтлоо оролдоно;* 2. хоригтой, цээртэй үйл; *энд тамхи татаж болохгүй!; хулгай хийж болохгүй.* ᠪᠣᠯᠤᠬᠤ ᠦᠭᠡᠢ

БОЛОХУЙЦ 1. болмоор; *муу болохуйц ус;* 2. тохирохуйц; *аль болохуйц их байвал сайн.* ᠪᠣᠯᠤᠬᠤᠢᠴᠠᠯ

БОЛРОНЦОР: болронцор чулуу хэлбэр янз бүр, талст бүхий болорын нэг зүйл; хатуу нь 3, хувийн жин 2,6—2,8. ᠪᠣᠯᠤᠷᠤᠨᠴᠤᠷ

БОЛТОЛ хүртэл; *арван цаг болтол; хоол болтол шийр зугаа* з ү й р; *үд болтол унтах.* ᠪᠣᠯᠲᠤᠯ ᠂

БОЛХИ 1. хийцээр бүдүүн муу, нарийн биш, эв хавгүй; *болхи хийцтэй эдлэл;* 2. бүдүүлэг, эв хавгүй; *болхи хөдлөх; болхи амьтан.* ᠪᠣᠯᠬᠢ

БОЛХИВТОР нилээд болхи. ᠪᠣᠯᠬᠢᠪᠲᠤᠷ

БОЛХИДОХ дэндүү болхи болох. ᠪᠣᠯᠬᠢᠳᠤᠬᠤ

БОЛХИДУУ баахан болхи. ᠪᠣᠯᠬᠢᠳᠤᠭᠤ

БОЛЦГО: болцго болцго хийх болцгор юмны үргэлжлэн хөдлөх. ᠪᠣᠯᠴᠤᠭᠤ

БОЛЦГОНОХ болцгор юмны болцго болцго хөдлөх байдал. ᠪᠣᠯᠴᠤᠭᠤᠨᠠᠬᠤ

БОЛЦГОР бөөрөнхийвтөр, цэлцгэр; *болцгор мод; болцгор хацартай.* ᠪᠣᠯᠴᠤᠭᠤᠷ

БОЛЦОЙХ болцгор болох. ᠪᠣᠯᠴᠤᠭᠠᠬᠤ

БОЛЦОЛЗОХ болцгор юмны болцос болцос хөдлөх байдал. ᠪᠣᠯᠴᠤᠯᠵᠤᠬᠤ

БОЛЦОН болцгор бөөрөнхий. ᠪᠣᠯᠴᠤᠨ

БОЛЦОС: болцос болцос хийх болцгор юмны байн байн хөдлөх. ᠪᠣᠯᠴᠤᠰ

БОЛЦУУ 1. харвалын сумны үзүүрт байдаг бөөрөнхийвтөр яс; *сумны болцуу;* 2. бөөрөнхийвтөр, сумны болцуу хэлбэртэй; *усний болцуу; сонгинын болцуу.* ᠪᠣᠯᠴᠤᠤ

БОЛЧИМ болгоомж, ул, суурь. ᠪᠣᠯᠴᠢᠨ

БОЛЧИМГҮЙ болгоомжгүй, суурьгүй, гэнэн, хөнгөмсөг; *болчимгүй хүн.* ᠪᠣᠯᠴᠢᠨ ᠦᠭᠡᠢ ᠬᠦᠨ

БОЛЧИМЛОХ болгоомжлох. ᠪᠣᠯᠴᠢᠮᠯᠠᠬᠤ

БОЛШГҮЙ болох төлөвгүй; *санаж болшгүй хэрэг; явж болшгүй газар; нөхөрлөж болшгүй хүн.* ᠪᠣᠯᠰᠢᠭᠤᠢ ᠦᠭᠡᠢ

БОЛЬНИЦ өвчтөнийг эмчлэн сувилах газар; *төв больниц; хүүхдийн больниц.* ᠪᠣᠯᠢᠨᠢᠴᠠ

БОЛЬШЕВИЗМ пролетарийн хувьсгалт хөдөлгөөн, хөрөнгөтний нийгмийг эв хамтын нийгэм болгон өөрчлөх Ленинний опол, ленинизм гэсэн үгтэй утга адил. ᠪᠣᠯᠱᠡᠪᠢᠵᠢᠮ

БОЛЬШЕВИК марксизм-ленинизмийн сургаалыг баримтлагчид. ᠪᠣᠯᠱᠡᠪᠢᠺ

БОМБО бомбын шажны сургаал ёсоор гэрээс гарч сүмд суух хүн; **бомбын шажин** (манай эрэнгийн эхэн буюу дорнод Хан улсын үед дэлгэрсэн шажин). ᠪᠣᠮᠪᠠ

БОМБОГОР бөөрөнхийдүү бөмбөгөр хэлбэртэй. ᠪᠣᠮᠪᠤᠭᠤᠷ

БОМБОЙХ бомбогор болох. ᠪᠣᠮᠪᠠᠬᠤ

БОНДГО: бондго бондго хийх бондгор юмны үргэлжлэн хөдлөх. ᠪᠣᠩᠭᠤ

БОНДГОНОХ бондгор юмны бондго бондго хөдлөх. ᠪᠣᠩᠭᠤᠨᠠᠬᠤ

БОНДГОР бомбогор, бонцгор. ᠪᠣᠩᠭᠤᠷ

БОНДОЙХ бондгор болох. ᠪᠣᠩᠭᠠᠬᠤ

БОНДОЛЗОХ бондгор юмны бондос бондос хийх. ᠪᠣᠩᠭᠤᠯᠵᠤᠬᠤ

БОНДОС: бондос бондос хийх бондгор юмны байн байн хөдлөх. ᠪᠣᠩᠭᠤᠰ

БОНО у р г а м а л хар үйлстэй адил, бөлхэн, хатуу нэг зүйл жимс. ᠪᠣᠨᠤ

БОНХГОР нэг үзүүр нь бүдүүвтэр бөгөөд бөөрөнхийдүү хэлбэртэй юм; *бонхгор шийдэм.* ᠪᠣᠩᠬᠤᠷ

БОНХОЙХ бонхгор болох, бонхойж харагдах. ᠪᠣᠩᠬᠠᠬᠤ

БОНЦГОР монцгор, бондгор. ᠪᠣᠨᠴᠤᠷ

БОНЦОЙХ бонцгор болох, бонцойж харагдах. ᠪᠣᠨᠴᠠᠬᠤ

БОНЦУУ бонцгор юм. ᠪᠣᠨᠴᠤ

БООВ гурилаар хийсэн идээ; *хэвийн боов; хавсай боов; салаа боов;* **нарийн боов** (чихэр

тос зэрэг зүйлийг хольж амталсан гурилан идээ); **чихэр боов** х о р ш.; **чихэр боовны** үйлдвэр (нарийн боов үйлдвэрлэх үйлдвэр); ☆ **таван салаа боов өгөх** (алгадан жанчих).

БООВЧИН боов хийх мэрэгшилтэй хүн.

БООГДОЛ боогдох байдал; **гачигдал боогдол; саатал боогдол** х о р ш..

БООГДОХ 1. боохын үйлдэгдэх хэв; 2. *хаагдах; боогдох хаагдах явдлаар бага.*

БООГДУУЛАХ боогдохын үйлдүүлэх хэв, хяхан хясах; *ажилчны хүсэл эрмэлзлэлийг боогдуулж үл болно.*

БООДЛОГО боодол.

БООДОЙ тэрэг чирэх малын хоолой доогуур торгох оосор.

БООДОЛ цаас бөс зэргээр хэсэглэн боосон зүйл; *нэг боодол лаа; нэг боодол даавуу.*

БООДОЛЛОХ юмыг боож цуглаж боодол болгох.

БООДОС юм боох уяа оосор боолт.

БООЛ 1. боолын эзэмшил ба феодалын үеийн нийгэмлэгт ямар ч эрх мэдэл, үйлдвэрлэлийн хэрэгсэлгүй бөгөөд эзэн ноёны бүрэн өмч болж, хөдөлмөр ба амь бие нь түүний мэдэлд орших хүмүүс; *босгоны чинь боол болъё үлгэр*; **боол зарц** х о р ш.; *боолын худалдаачин; албат боол; боолын байдал;* 2 .аравт, түүнээс дооших модыг дарах, хөзрийн нэг дүрс.

БООЛТ юм боох оосор бөс зэрэг зүйл; *хүүдийний боолт; гутлын боолт; шархны боолт;* ☆ **толгойн боолт** х у у ч и р с а н (эхнэр хүний толгойн чимэг).

БООЛЧЛОГДОХ боолчлохын үйлдэгдэх хэв; бусдын боол болж байх, бусдын эрхэнд байх, *дорно зүгийн боолчлогдсон ард түмэн нойроос сэрэв.*

БООЛЧЛОЛ боолчлох үйлийн нэр.

БООЛЧЛОХ дарлан мөлжих, боол болгон зарах; *Монголын ард түмнийг феодал ноёд хүгжгэт хувилгаад боолчлон зовоож байв.*

БООЛЧЛУУЛАХ 1. боолчлохын үйлдүүлэх хэв; 2. боолчлогдон дарлагдах.

БООМ голдуу малд, заримдаа хүнд тохиолдох халдварт өвчин; ☆ **гутлын боом** (монгол гутлын зулаг түрий хоёрын уулзар).

БООМИЛОХ 1. хоолойгоор оосорлон боох; *цагаантан, хүнийг боомилон алж байв; боомилон үхэх;* 2. боож хяхах.

БООМИЛУУЛАХ 1. боомилохын үйлдүүлэх хэв; 2. хяхуулах.

БООМТ 1. явах зорчих замд тавьсан саад; *саад боомт; замын боомт;* 2. хил хязгаарын орох гарах зам нэвтэрсэн сүв; *хилийн боомт;* 3. халхавч хэрэмд нэвтрэн орох хаалга; *боомт хаалга;* 4. далайн эрэг дэх хөлөг онгоц зогсох буудаллахад зохицуулан бэлтгэсэн газар; *далайн боомт;* 5. ш и л ж с э н саад тотгор; *боомт тавих; боомт болох.*

БООМТЛОГДОХ боомтлохын үйлдэгдэх хэв.

БООМТЛОХ саад тотгор учруулах, боомт хийх.

БООМТЛУУЛАХ боомтлохын үйлдүүлэх хэв; 2. боомтлогдох.

БООМТОХ боом өвчин тусах.

БООМЬ бугуйл, цалам.

БООМЬДОХ бугуйлдах.

БООРЦОГ гурилаар хийсэн боовны зүйл; **боорцог боов** х о р ш..

БООС хээлтэй; *боос ингэ; боос гүү; боос болох.*

БООСОХ боос болох, мал гөрөөсний хээл олох.

БООСРОХ боос болох.

БООСТОХ мал гөрөөсний хэвэлд хээл тогтох.

БООХ 1. цуглах, баглах; *ваадаид боох; хэсэг хэсэг боох;* 2. уях, хүлэх; *хүүдийн ам боох; сураар боох; шарх боох; бэртэнгэ боох;* 3. нарийсах, бачуурах; *хоолой боох;* 4. ш и л ж с э н хориг хийх, хаах; *цас боох; замыг боох; амь нь боох* (үг хэлүүлэхгүй болгох); 5. үнэрхэх; *боогсод хэлж өгсөнгүй; баячууд хөсгөөр боодог байв;* 6. боомилох; *боож алах, боож үхэх.*

БООХОЙ чоно; *борооны түрүү шороо, боохойн түрүү хэрээ* х у у ч.;

БООЦ I хаац; **хаац бооц** х о р ш.; *усны бооц сэтэрчээ.*

БООЦ II бооцоо, мөрий.

БООЦЛОХ I бооц хаац хийх; *ус бооцлох.*

БООЦЛОХ II бооцох, мөрийцөх; *бооцолж тоглох.*

БООЦОЛДОХ *харилцан мөрийцөх.*

БООЦОО мөрий; *бооцоотой наадах; бооцоо алдах.*

БООЦОХ мөрийцөх, бооцолдох.

БОР I 1. хар цагаан хоёр хольцолдсон өнгө, зүс; *бор морь; бор даавуу; бор царайтай;* **бор хар, хар бор** (харавтар бор); 2. ш и л ж - с э н дорой, буурай, хөөрхийлөлтэй; **хар бор ажил** (аар саар ажил); *бор хирийн хүн; бор зүрх;* **бор гэр** (аар саар юм хураах буюу галлах илүү гэр); 3. ургамал, амьтны нэрд оролцоно; **бор азрага** а м ь т а н (бялзуухай, таргалжинтай адил, өвөг хөххөн, нуруундаа бараан бидэртэй, ямагт сүрэглэж ниснэ); **бор галуу** а м ь т а н (зэрлэг галууны нэг зүйл); **бор гөрөөс** а м ь т а н (ой тайгад байдаг нэг зүйл хос туурайт амьтан); **бор шувуу** а м ь т а н (бие жижиг нэг зүйл болжмор); **бор улиас** у р г а м а л (ой дотор голыг ирмэглэн ургана; навч нь улиасны навчаас багахан, бүдүүн нь гурав дөрвөн тэвэр хүрдэг нэг зүйл мод); **бор улиангар** у р г а м а л (25—30 метр өндөр, хальс бор цайвар, өндөр хэлбэртэй бор цайвар навчтай, навчны урт нь 4—7 см. нэг зүйл мод); **бор маз** у р г а м а л (тариалангийн зах сул газар тарина; иш нь үетэй болоод хөндий, навч нь их болоод хушуутай, үрээс нь тос авна); **бор сойх** у р г а м а л (иш навч сойхтой адил, амт гашуун, хээр болон гэрт ургана); **бор уд** у р г а м а л (улаан уд модны өөр нэр); **бор бургас** у р г а м а л (ой хярд ургана; дурс харавтар, навч дүгрэгхэн болоод зузаан, гол нь улаан нэг зүйл мод); **бор шаваг** у р г а м а л (өндөр нь 5—8 см., говь талын бүсэнд ургадаг; бог мал мөн тэмээ бор шавагны мөчирт дуртай, үхэр адуунд зун намрын цагт тэжээлтэй); **бор төлөг** у р г а м а л (навч улаавтар, мөчирлөг нэг наст ургамал; өндөр нь 15—25 см., монгол орны говь талын бүсэнд ургана; бас зарим газар шар толгой гэдэг); **бор бударгана** у р г а м а л (өндөр нь 20—25 см. мөчирлөг, мөчрийн дагуу мөхлөгтэй, монгол орны говь-талын бүсэнд ургана): **бор элгэнэ** у р г а м а л (олон наст бутархаг ургамал; өндөр нь 3—5 см., цэцэг ягаавтар, монгол орны говь, говь талын бүсэнд ургадаг, зун намрын цагт бог мал иднэ); **бор харгана** у р г а м а л (өндөр нь 1,5—2 метр, шар ногоон хальстай, монгол орны говь талын бүсэнд ургана; бор харганы мал идвэл ам нь гэмтдэг гэж хэлдэг); **бор таар** у р г а м а л (тал, говь талын бүсэнд ургадаг нэг зүйл ургамал); **бор хушуу** а м ь т а н (нүд улаавтархан, хушуу харавтар, толгой ар сүүл цөм харавтар болоод цагаан чандартай нэг зүйл бялзуухай); **бор харагчин** а м ь т а н (үнсэн өнгөтэй, хүзүү бараан, өвчүү цагаан, явахдаа сүүлээ өргөдөг нэг зүйл бялзуухай); **бор туулай** а м ь т а н (бидэртэй бор саарал зүстэй, сүүлний дээд тал боровтор, доод тал цагаан, сүүлийн үзүүрт шар үс бий); **бор харх** а м ь т а н (урт нь 15—20 см, сүүл нь 10—12 см, хүнд нь 500 грамм хүрдэг, өнгө нь боровтор нэг зүйл хулгана); ☆ **бор дарс** (архи айраг хольж найруулан нэрж гаргасан буюу айрагт элдэв жимсний зүйл хольж исгэн нэрж гаргасан архи); **бор хоол** (а. мах буюу махтай хоол; *бор хоол идэх;* б. сүүнээс бусад хоол; *хүүхдээ бор хоолонд оруул);* **бор хоног** (шөнө; *шөнийн бор хоногт л гэртээ ирдэг хүн; шар нар, бор хоног);* **бор хараа** (үдшийн гэгээ; *бор хараа тасрах);* **бор шар** (а. бор өнгө дийлэнх шар өнгө зүс; б. дотрын өвчин; *би бор шарын гэмтэй хүн).*

БОР II халиуны зулзага.

БОР III техник болон эмнэлэгт хэрэглэдэг химийн махбод; *борын хүчил.*

БОРВИ I шагайт амьтны шагайны дорхи бяцхан яс; *борвиороо бор эсгий цувуулж, шаантаараа шар эсгий цувуулах* үлгэр.

БОРВИ II бяцхан хөхүүр сав; *нэг борви айраг уув.*

БОРВИ III 1. өсгийн дээд бүдүүн шөрвөс; 2. тахилзуур; *борви бохирохгүй ажиллав.*

БОРГИО I урсгал усны хүрхрээ.

БОГИНО II шороо хужир холилдон хөөрөн хөвсийсөн газар.

БОРГИОТОХ боргио гарах, тогтох.

БОРГОЛЖИН: борголжин сахал хушуу тойрон ургасан сахал.

БОРГООХ боргоход хүргүүлэх.

БОРГОХ хоргоох, нохой ээрэн хоргоож хуцах; *боргодог нохой.*

БОРГОЦОГ боргоцой.

БОРГОЦОЙ хуш модны самрын үүр.

БОРГОШИХ 1. бойжиж торнин тэсвэртэй болох; *боргошсон хүүхэд;* 2. шарх сорви зэрэг эдгэрэн чийрэг болох; 3. хатуужиж чийрэг болох.

БОРГОШУУ хатуужил тэсвэр олсон .

БОРГОШУУЛАХ боргошихын үйлдүүлэх хэв; тэсвэртэй болгох.

БОРГУУЛАХ 1. боргохын үйлдүүлэх хэв; 2. боргоогдох.

БОРДГОР бордгоо, тэжээл.

БОРДМОЛ бордох үйлийн нэр; *бордмол гахай; бордмол шар.*

БОРДОО 1. тэжээл, мал тэжээвэрт идүүлэхээр бэлтгэсэн өвс тэжээлийн зүйл; *малын бордоо;* 2. газрын ургац шимийг дээшлүүлэхийн тул бордох юм; *химийн бордоо; хиймэл бордоо; эрдэс бордоо.*

БОРДОХ I 1. малд тусгай бэлтгэсэн тэжээл идүүлэх; *өвөл цагт малаа борддог;* 2. газрын шимийг ямар нэг тэжээлийн зүйлээр дээшлүүлэх; *газрыг өтөг шивхээр борддог.*

БОРДОХ II хэтэрхий бор болох.

БОРДУУ боровтор.

БОРДУУЛАХ бордохын үйлдүүлэх хэв; тэжээгдэх.

БОРДУУР бордох юм.

БОРЖИН I олон зүйлийн чулуулгаас бүтсэн нэг зүйл чулуу.

БОРЖИН II: **боржин нугас** амьтан гэрт тэжээдэг ногоон нугастай адил нэг зүйл шувуу.

БОРЗОН I малд өгдөг нэг зүйл шороон хужир, бас арьс элдэхэд хэрэглэнэ.

БОРЗОН II ээзгий ааруул мэтийг шар тостой хутгамш болгон хийсэн нэг зүйл идээ.

БОРЛОГ цагаан цайвар хольцолдсон бор зүс; *борлог морь.*

БОРЛОН хоёрдох жилийн нүүр үзэж байгаа ишиг.

БОРЛОХ I 1. бор болох; *хүүхдийн царай наранд борлов;* 2. чанасан зүйл дутуу болох; *мах борлов;* 3. шилжсэн хатуужих, чийрэгжих; *ажилд борлох.*

БОРЛОХ II зарагдах, худалдагдах; *мухлагийн хүлээн авсан бараа борлож гүйцэв.*

БОРЛОХ III луйвардах, луйварчирхуу зан гаргах.

БОРЛУУЛАХ I борлох I-ийн үйлдүүлэх хэв; 2. бор болгох.

БОРЛУУЛАХ II борлох II-ын үйлдүүлэх хэв; зарж худалдаж зүйл дуусах; *энэ улирлын бараа борлуулах төлөвлөгөө;* ☆ **хувиа борлуулах** (хувьдаа ногдсон зүйлийг гүйцэтгэх); **амиа борлуулж, довоо шарлуулах** (амиа зөвхөн аргацаах).

БОРОВТОР нилээд бор.

БОРОГ I: **борог өвс** хуучин хагд өвс.

БОРОГ II: **борог мах** өөхгүй хар мах.

БОРОГДОХ I мах өөхгүй хардаж идэхэд тохиромжгүй болох.

БОРОГДОХ II борог өвс хэтэрхий ихдэх; *манай хонины билчээр борогдоод байна.*

БОРОГЛОХ малд борог идүүлэх.

БОРОГЛУУЛАХ бороглохын үйлдүүлэх хэв.

БОРОГЧ эм малын бор зүстэйг; *борогч гүү.*

БОРОЛДОЙ: боролдой болжмор амьтан өнгө гуа болжмортой адил, байдал бүднэтэй төстэй бяцхан шувуу.

БОРОЛЖ ургамал намаг, голын эрэг газар ургадаг нэг зүйл хуш мод; монгол орны Хэнтий, хангайн нуруунд ургана.

БОРОЛЖГОНО амьтан цагаан цавьгүй, бараан хэрэмтэй адил хэрэм.

БОРОЛЗГОНО ургамал хатангир газрын голын захаар ургана; иш нарийн, салаа үлэмж, ноорсон дурстай, шар цэцэгтэй, зарим газар ороогуур ороолгуу ч гэнэ; тогооны шүүр хийдэг мод.

БОРОЛЗОЙ ургамал говь, говь-талын бүсэнд ургадаг нэг зүйл ургамал.

БОРОН амьтан шүлүүсний адил болоод бяцхан мануулаас ихээхэн нэг зүйл амьтан.

БОРОО (Н) 1. агаарын тундсын нэг зүйл болох усан дуслууд; *үүл гарч бороо оров;* **бороо арилах** (бороо зогсох); **бороо намжих** (бороо бага болох); **бороо зөөлрөх** (бороо ширүүнгүй болох); **бороо цайрах** (бороо орон ирж үзэгдэх); **бороо сэг болох** (бороо түр зогсох); **бороо шимтэх** (бороо орж өн болох).

БОРОО II ясны бороолсон бэрсүү; *бороо тогтох.*

БОРОО III: **сумны бороо** сумны ясан болцуу.

БОРООЛОХ бороо тогтох; *бэртсэн яс бороолон эдгэрэв.*

БОРООРХОГ бороо элбэг; *энэ жил бороорхог жил.*

БОРООТОЙ 1. бороо элбэгтэй; 2. бэртэнгэ, бороо тогтсон; *бороотой бор морь.*

БОРООХОЙ жанчих цохиход зориулсан торлог мод.

БОРООХОЙДОХ бороохойгоор цохих.

БОРООХОЙДУУЛАХ 1. бороохойдохын үйлдүүлэх хэв; 2. бороохойдогдох.

БОРООШИХ бороо элбэгших, бороо орох шинжтэй болох.

БОРТГО I бургасаар хийсэн, таван жин тариа багтах хэмжүүр сав.

БОРТГО II 1. жижигхэн ухмал модон хувин; 2. бууны сумны хонгио; 3. лаа цутгах хэв.

БОРЦ 1. урь идүүлэн хатаасан мах; 2. ш и л ж с э н хатангир туранхай.

БОРЦЛОХ 1. борц хийх; 2. ш и л ж с э н хатаах, шарлаах зовоох.

БОРЦЛУУЛАХ 1. борцлохын үйлдүүлэх хэв; 2. борцлогдох.

БОРЦОР бордуу.

БОРЧИХ 1. эвдэж бусниулах; 2. ш и л ж с э н номхотгох, эрхшээлдээ оруулах, зөөлрүүлэх; **сэтгэл борчих** (сэтгэлийг номхотгох).

БОРШИХ I шингэн юмны чаналт нь хэтэрснээс болж дэндүү хурц амттай аагтай өтгөн болох; *боршсон шөл; цай борших.*

БОРШИХ II бор шинжтэй болох, борлох.

БОСГО 1. үүд хаалганы дор байх хөндлөн мод; *босгон дээгүүр алхах;* 2. х у у ч и р с а н төв суурин газрын шадар залгаа байгаа; *босго өртөө; босго суман.*

БОСГОЛ оргож яваа хүн, оргодол.

БОСГОХ босохын үйлдүүлэх хэв, босоход хүргүүлэх; **хөл дээр нь босгох** (буурч доройтсон зүйлийг дахин сэргээх).

БОСГУУЛАХ босгохын үйлдүүлэх хэв.

БОСЛОГО засаг төрийг эсэргүүцэн олноор зохион байгуулалттай хөдлөх; *18-р зууны үе дэх ардын бослого; бослого гаргах; бослогын толгойлогч.*

БОСОЛТ боссон нь.

БОСОО дээрээс доош шулуун эгц; *босоо шугам; босоо зогсох; босоо зул* (лаа); **босоо бүслүүр** (уулыг хөрс, ургамлын байдлаар хуваан ангилсан бүслүүр); **босоо шуурга** (цас салхинд хийсч 2-оос 100 метр хүртэл өндөрт бургин гарах шуурга).

БОСОХ 1. хэвтээ суугаа хүн амьтан буюу юм дээш болон босох зогсох; *суудлаас босох; орноос босох; өглөө босох;* 2. бослого гаргах; *ард түмэн хаант засгийг эсэргүүцэн бослоо;* 3. цогцлогдох, тогтох; *шинэ барилга босов;* 4. үүсэх ,дэгдэх; *шороо босох нь; хэрэг босчээ;* 5. оргох, зайлах; *өнөөх чинь босоод явчихсан гэнэ.*

БОСТОН нэг зүйлийн ноосон нэхмэл даавуу; *монгол бостон.*

БОСХУУЛ оргож буруулан яваа хүн.

БОТАНИК ургамал судлал.

БОТАНИКЧ ургамал судлаач.

БОТГИРОХ шингэн идээний зүйл өтгөрөн дуурмаг болох; *ботгирсон тараг.*

БОТГО тэмээний нэг настай төл; *ботготой ингэ.*

БОТГОЛОХ ботго төрүүлэх; *ботголсон ингэ.*

БОТИЛОХ ном зохиолыг боть болгон хуваах.

БОТУУЛ у р г а м а л ойт хээр, хээрийн бүс, мөн хангайд ургадаг нэг зүйл үет ургамал, бус бутаар ургана.

БОТЬ ном зохиолын хэсэглэсэн дэвтэр; *данжуур 225 боть; нэвтэрхий толь 50 боть.*

БОХИЛОХ бохий нь арилгах, цэвэрлэх.

БОХИНДОХ бачимдах, тэвдэх; *ажилдаа бохиндох.*

БОХИО I бохир, бузар; **бохир бохио** х о р ш.,

БОХИО II 1. нүсэр юм, эв хавгүй; 2. таатай байдалтай биш; ☆ **бохио нугас** а м ь т а н (боржин нугаснаас томхон, хушуу сунамхай, мах нялуун, загас идэштэй).

БОХИОРОХ I бохир бохио болох.

БОХИОРОХ II нүсэр болох, эв хавгүй болох.

БОХИОРУУЛАХ бохирохын үйлдүүлэх хэв; бохио болгох.

БОХИР I буртагтай, хиртэй, муухай, цэвэр биш; *бохир буртаг; бохир гараар барьж үл болно; бохир муухай газар.*

БОХИР II 1. хүний гар хөлийн дотогш муруй; *бохир хөлтэй хүүхэд;* 2. гар хөлийн барих зорчиход дэм олохгүй; 3. болхи, бүдүүлэг.

БОХИРДОХ хэтэрхий бохир болох.

БОХИРЛОХ бохир болгох.

БОХИРОХ I хүн амьтны хөл нугарах, нугасхийх; *бухэл өдрийн турш борви бохиролгүй; бохирч суух.*

БОХИРОХ II бохь болох, бохьтой болох.

БОХИРТОХ улмаар бохир болох.

БОХИРУУЛАХ 1. бохирохын үйлдүүлэх хэв; 2. бохирогдох.

БОХИСХИЙХ түр бохирох; *борви бохисхийгээд авъя.*

БОХЬ I хар модны хатаж хүрэн болсон давирхай; *бохь зажлах.*

БОХЬ II гансны дотор тогтох муухай үнэртэй хар юм; *гансны бохь.*

БОХЬ III буурын орооны үед шилнээс нь гарах хатан үнэртэй харавтар заар; *буурын бохь.*

БОХЬ IV хуучирсан гурван үе болсон боол.

БОХЬ V: **бохь өвс** ургамал элсэрхэг ба зөөлөн хөрстэй газар бутлан салаалж ургана; өндөр нь 30 см. орчим, иш салааны бүдүүн нь дэрсний хир, цэцэг шар, өнгө цайвар ногоон, таслах буюу холтолбол сүү мэт юм гарах бөгөөд хатахдаа харлана; амт гашуувтар, мал бүхэн иднэ, шим тэжээл сайн.

БОХЬДОХ хэтэрхий бохьтой болох.

БОХЬТОХ бохь тогтох; *ганс бохьтох.*

БОШГО I босго, хаалганы доод талын хөндлөн мод; **бошго гишгүүр** (үүдэнд хөл арчихад зориулсан сараалжит жааз).

БОШГО II хуучирсан хушуу тамга сумын захиргааны газрын алба хөөж нийлүүлэгч; *сумын бошго.*

БОШИГ 1. зарлиг, заншил, суртал, зөвшөөрөл; **бошгийг халах залуучууд** (зарлигийг халах залуучууд); **бошиг соёрхох** (зөвшөөрөх); **бошиг гуйх** (зөвшөөрөл хүсэх); 2. иш, үндэс; **бошиг үзүүлэх** (иш үзүүлэх); **иш бошиг** хорш..

БОШИНЗ урт цамц, дан дээл.

БӨВ: бөв бөөрөнхий маш бөөрөнхий.

БӨВГӨНӨХ бөвгөр юмны үргэлжлэн хөдлөх байдал.

БӨВГӨР бөөрөнхийвтөр юмны зохисгүй.

БӨВНӨХ 1. ярих хэлэлцэхдээ дутуу хэтүү тодорхойгүй хэлэлцэх; 2. дөнгөж цөвтнөн хөдлөх; *ажилд бөвнөж л байна.*

БӨВӨР бөвөөлжний өөр нэр.

БӨВӨӨЛЖГӨНӨ амьтан бөвөөлжгөний намын шувуу; өнгө эрээн, хэвэл цагаавтар, жигүүр ба сүүл хар болоод цагаан судалтай, толгой дээр өвөгтэй, хушуу хар урт бөгөөд монхор.

БӨВӨӨЛЖИН амьтан хушуу урт, өнгө алаг, толгойд өвөгтэй бөө бөө гэж дуугардаг нэг зүйл шувуу; өвөөлж ч гэдэг.

БӨГ шагаа ясны түрүүлгэн этгээд; зарим газар хонь, зарим газар ямаа ч гэдэг.

БӨГЖ юманд чимэг болгох буюу бэхлэхээр хийсэн зүйл; *бөгжтэй авдар; хутганы бөгж*

БӨГЖЛӨХ юмыг бөгжөөр бэхлэх буюу янзлах.

БӨГЖЛҮҮЛЭХ бөгжлөхийн үйлдүүлэх хэв.

БӨГЛӨЛТ бөглөсөн нь.

БӨГЛӨРӨХ битүүрэх, тагларах; *усны цорго бөглөрчээ; ганс бөглөрөх.*

БӨГЛӨӨ бөглөх юм; *лонхны бөглөө; шилний бөглөө; бөглөө авах; онгорхойн бөглөө цоорхойн таглаа болгох.*

БӨГЛӨӨС бөглөсөн юм; *шүдний бөглөөс ховхорч унав.*

БӨГЛӨХ 1. хаах, битүүлэх, таглах; *лонхыг бөглөөгөөр бөглөх; чих бөглөх; зам бөглөх;* 2. шилжсэн муухан гүйцэтгэх; **ор бөглөх; ам бөглөх** (дутмаг зэрэмдэг хийж муухан гүйцэтгэх); **ор нэр бөглөх** (ор нэрийн төдий байх); **орон тоо бөглөх** (орон тоог эзлээд байх); ☆ **өр бөглөх** (өр төлөх).

БӨГЛҮҮ 1. хоолой сөөнгө; *бөглүү хоолойтой хүн;* 2. эндээс тэнд хүрэх хоорондын зай; *бөглүү нь хир вэ?;* 3. алс хол; *бөглүү газар суух.*

БӨГЛҮҮЛЭХ бөглөхийн үйлдүүлэх хэв, бөглөгдөх.

БӨГӨЛДРӨГ юмны гарын хуруунд сэгэлдрэх оосор; *ташуурын бөгөлдрөг.*

БӨГӨНЦӨГ утас ээрэхэд ээрүүлийн савх модонд хумс тавьж хумисан нь.

БӨГӨӨД холбоос; *сэргэлэн бөгөөд гавшгай.*

БӨГӨӨТӨЛ байтал, атал, мөртөө; *тарган мах бөгөөтөл амтгүй; нартай бөгөөтөл дулаан биш.*

БӨГС 1. хүн амьтны биеийн бэлхүүснээс доошхи хэсэг; *хонины махыг цээж бөгсөөр нь салгах;* 2. юмны ар, хойт, доод тал; *тэрэгний бөгс; бууны бөгс; модны бөгс;* 3. цуваа юмны адаг сүүл, хойт тал; *жагсаалын бөгс;* 4. шилжсэн үйл явдлын төгсгөл, сүүл шувтрага; *хэргийн бөгс; бөгсий нь харж байж бол.*

БӨГСЛӨХ бөгсий нь салгах.

БӨГТГӨР урагш бөхийсөн юм; *бөгтгөр нуруутай морь.*

БӨГТИЙЛГӨХ бөгтийхийн үйлдүүлэх хэв.

БӨГТИЙХ бөгтөр болох.

БӨГТӨӨ I морин ачаа; *бөгтөө хөтлөх.*

БӨГТӨӨ II уулын ялихгүй хотос газар, өгтөө ч гэнэ; *тэр бөгтөөгөөр даваад яв.*

БӨГТӨР бөхгөр, бөгтгөр; *бөгтөр хүн; бөгтөр уурга;* **бөгтөр яргай** у р г а м а л (нэг зүйл яргай).

БӨГТӨРДӨХ хэтэрхий бөгтөр болох.

БӨГТРӨГ нугасхийн тавьж болохуйц зүйл.

БӨГТРӨХ нугасхийх, нугалан юмны дээгүүр тохож тавих; *мах бөгтрөх; хашаан дээгүүр бөгтрөх.*

БӨГТРҮҮДЭХ бөгтрөхийн үйлдүүлэх хэв; бөгтрөгдөх.

БӨГЦГӨНӨХ бөгцгөр юмны бөгцөг бөгцөг хийх.

БӨГЦГӨР тахир бөхгөр бөгтгөр.

БӨГЦИЙЛГӨХ бөгцийхийн үйлдүүлэх хэв.

БӨГЦИЙХ бөгтгөр бөгцгөр болох.

БӨГЦӨГ: бөгцөг бөгцөг хийх бөгцгөр юмны үргэлжлэн хөдлөх.

БӨГЦӨГ: бөгцөг няслах шагаа орхиж адил дүрсээр нисалж наадах.

БӨГЦӨЛЗӨХ бөгцгөр юмны бөгцөс бөгцөс хийх.

БӨГЦӨС: бөгцөс бөгцөс хийх бөгцгөр юмны байн байн хөдлөх.

БӨДНӨ а м ь т а н ятууны төрлийн хээрийн шувуу; зарим газар тэжээж харилцан зодолдуулан наддаг, бие жижиг, оготор сүүлтэй, хөхөвтөр өрөвлөгтэй; **бөдний сүүл** у р г а м а л (газарт хэвтээгээр ургадаг түрүүт өвс).

БӨЖ а м ь т а н янз байдал цагаан бугатай адил бөгөөд дөрвөн эвэртэй нэг зүйл гөрөөс.

БӨЖИГ бүжиг.

БӨЖИГЛӨХ бүжиглэх.

БӨЖИГЧ бүжигч.

БӨЖИЛХИЙЛЭХ өндөр өөд авирах, дээр газар гарах зэрэгт сүрдэж айх.

БӨЖИН туулайн сая төрсөн зулзага.

БӨЖИНХИЙ бөжин.

БӨЖРӨГЛӨХ бусдад биеэ доор болгож чармайн нийлүүлж явах.

БӨЛГӨН юмны сул, буурай, туяхан, хэврэг; *бөлгөн биетэй хүүхэд; бөлгөн саваа мод.*

БӨЛГӨӨ б и ч и г өгүүлбэрийн төгсгөлд тавих үг, билээ, авай; *хамт суух бөлгөө; тэр ууланд ан гөрөөс маш үлэмж бөлгөө.*

БӨЛЗӨГ 1. хуруунд зүүх чимэг; *алтан бөлзөг;* 2. гархи, цагариг.

БӨЛЗӨГЛӨХ 1. бөлзөг зүүх; 2. юманд гархи углан тогтоох.

БӨЛХӨН бөлгөн.

БӨЛЦГӨР аньсга зовхи цэлцгэр, хөөнгөтсөн юм; *бөлцгөр нүд; бөлцгөр царайтай.*

БӨЛЦИЙЛГЭХ бөлцийхийн үйлдүүлэх хэв; бөлцгөр болгох.

БӨЛЦИЙХ бөлцгөр болох, бөлцийж харагдах.

БӨЛЦӨГ: бөлцөг бөлцөг хийх бөлцгөр юмны үргэлжлэн хөдлөх.

БӨЛЦӨГНӨХ бөлцгөр юмны бөлцөг бөлцөг хийх байдал.

БӨЛЦӨН бөлцийсөн, бөлцгөр; *бөлцөн нүдтэй.*

БӨЛЦӨС: бөлцөс бөлцөс хийх бөлцгөр юмны байн байн хөдлөх.

БӨМ бөмнөлдсөн, бөөрөнхий; *бөм шороо; бөм ус.*

БӨМБИЙ бөмбөгөр юм; *өвхөн бөмбий араг сэгсээ* о н ь с г о.

БӨМБИЙЛГӨХ бөмбийхийн үйлдүүлэх хэв, бөмбөгөр болгох.

БӨМБИЙЛӨХ 1. нялх хүүхдийг хайрлан танирлах; 2. юм хумыг эмхэлж цом болгох; 3. юмыг бөмбий болгох.

БӨМБИЙХ бөмбөгөр болох; *гэрийг цас бөмбийтөл даржээ.*

БӨМБӨГ I сураар сүлжиж хийсэн дотроо хөндийтэй бөөрөнхий, морин дээрээс харваж наадна; *бөмбөг харвах;* 2. уян эдээр хийсэн цул буюу дотроо хийтэй бөөрөнхий зүйл; *бөмбөгөөр тоглох; бөмбөг өшиглөх; бөмбөг харилцах;* **гар бөмбөг** (татсан тор дээгүүр бөмбөг давуулан шидэж наадах тоглоом, нэг багт зургаан хүн байна); **хөл бөмбөг** (баг болон талцаж бөмбөгийг өшиглөн хөөж эсрэг багийн хаалганд оруулан наадах тоглоом); **одон бөмбөг** (ширээн дээр тор татаж жижиг бөмбөгөөр давуулан наадах тоглоом, нэг талд нэг буюу хоёр хүн байна); **сагсан бөмбөг** (сагс мэт дүүжилсэн торон саванд оруулан наадах тоглоом); 3 тэсрэх бодис агуулсан дэлбэрэх сум; *галт бөмбөг; атомын бөмбөг;* **бөмбөгөн цахилгаан** (хэд хэдэн секундээс

хагас минут хүртэл агаарт аажим явдаг галт бөмбөг, заримдаа тэсрэнэ).

БӨМБӨГ II: **бөмбөг бөмбөг хийх** бөмбөгөр юмны үргэлжлэн хөдлөх байдал.

БӨМБӨГДӨГЧ тэсрэх бөмбөг хаягч; *бөмбөгдөгч онгоц.*

БӨМБӨГДӨХ тэсрэх бөмбөг хаях; *хотыг бөмбөгдөх.*

БӨМБӨГДҮҮЛЭХ 1. бөмбөгдөхийн үйлдүүлэх хэв; 2. бөмбөгдөгдөх.

БӨМБӨГНӨХ 1. бөмбөгөр юмны бөмбөг бөмбөг хөдлөх байдал; 2. шилжсэн айчичрэх, дагжих; *шил хагалсандаа болоод бөмбөгнөтөл чичирч байв; даарсан хурга бөмбөгнөж хэвтэнэ.*

БӨМБӨГНҮҮЛЭХ бөмбөгнөхийн үйлдүүлэх хэв.

БӨМБӨГӨН: бөмбөгөн цэцэг ургамал навч ногоон болоод харавтархан, хавар цэцэглэнэ, цэцэг таван хэлтэстэй, хүйс улаан цагаан хоёр зүйл бий; **бөмбөгөн нум** (бөмбөгийг үсрүүлэн явуулах гичиргүй нум).

БӨМБӨГӨР бөөрөнхийдүү **хэлбэртэй**; *бөмбөгөр гэр; бөмбөгөр араг.*

БӨМБӨГЧ бөмбөг **хийдэг мэрэгжилтэй** хүн.

БӨМБӨЛЗӨХ бөмбөгөр юмны бөмбөс бөмбөс хөдлөх байдал.

БӨМБӨЛӨГ бөөрөнхий дүрс; **бөмбөлөг сэвэг** (бургасаар дүгрэгхэн сүлжиж хийсэн сав); **бөмбөлөг боорцог** (бөөрөнхий хэлбэртэй боловсруулж хийсэн нэг зүйл боов).

БӨМБӨНЦӨГ бөөрөнцөг, бөмбөөхий.

БӨМБӨӨХИЙ исгэсэн гурилаар хөөлгөж хийсэн нэгэн зүйл идээ.

БӨМБӨР хоёр талыг арьсаар бүрж хийсэн, дэлдэх хөгжмийн зэвсэг, жижиг хэнгэрэг; *бөмбөр дэлдэх; бөмбөр цохих.*

БӨМБӨРДӨХ бөмбөр хөгжим цохих.

БӨМБӨРӨХ юмны өнхрөх, явах, хөдлөх; *бөмбөг газрын руу бөмбөрөв; нялбас бөмбөрөх.*

БӨМБӨРЦӨГ 1. диаметрээр нь эргүүлэхэд гарах геометрийн дүрс; 2. тийм хэлбэртэй юм; *агаарын бөмбөрцөг;* **газрын бөмбөрцөг** (газар нэрт гариг); **бөмбөрцгийн зүүн хагас** (бөмбөрцгийн зургийн босоо шугамаар хувааж тэг шугамаас зүүн тийших хэсэг, Ази, Европ, Африк, Австраль тив); **бөмбөрцгийн баруун хагас** (мөн тэг шугамаас баруун **тийших** хэсэг, Америк тив).

БӨМБӨС: бөмбөс бөмбөс хийх бөмбөгөр юмны байн байн хөдлөх.

БӨМБӨХ цэвэр чадамгай явах, хөдлөх; *саарал морь бөмбөж явна; хүүхэд бөмбөрөн бөмбөж гүйв.*

БӨМНӨЛДӨХ бөөгнөрөх, бөөгнөх.

БӨМӨРЦӨГ бөмбөрцөг мэт болоод жижиг юм.

БӨНДГӨР асар жижиг биш бөгөөд бөөрөнхийвтэр бөмбөгөр хэлбэртэй юм; *бөндгөр сав; бөндгөр шил.*

БӨНДИЙЛГӨХ бөндийхийн үйлдүүлэх хэв, бөндгөр болгох.

БӨНДИЙХ 1. бөндгөр болох, бөндийж харагдах; *тэнд нэг юм бөндийж байна.*

БӨНДӨГ: бөндөг бөндөг хийх бөндгөр юмны үргэлжлэн хөдлөх.

БӨНДӨГНӨХ бөндгөр юмны бөндөг бөндөг хөдлөх байдал.

БӨНДӨГНҮҮЛЭХ 1. бөндөгнэхийн үйлдүүлэх хэв; 2. айх эмээхэд хүрүүлэх; *хөгшин ч харин хэдэн хүүхдээ бөндөгнүүлэв.*

БӨНДӨЛЗӨХ бөндгөр юмны **бөндөс бөндөс** хөдлөх байдал.

БӨНДӨС: бөндөс бөндөс хийх бөндгөр юмны байн байн хөдлөх.

БӨНЖГӨР бөндгөр бөөрөнхий хэлбэртэй юм.

БӨНЖИГ: бөнжиг бөнжиг хийх бөнжгөр юмны үргэлжлэн хөдлөх.

БӨНЖИГНӨХ бөнжгөр юмны бөнжиг бөнжиг хөдлөх; *ээмгийн бөнжигнүүр нь бөнжигнөж байв; өвгөний толгой бөнжигнөх болжээ.*

БӨНЖИГНҮҮЛЭХ 1. бөнжигнэхийн үйлдүүлэх хэв; 2. айх эмээхэд хүрүүлэх.

БӨНЖИГНҮҮР шүр, оюу, шил мэтээр хийсэн бөнжигнөн унжих чимгийн зүйл; *бөнжигнүүртэй эмэг.*

БӨНЖИЙХ бөнжгөр болох, бөнжийж харагдах.

БӨНЖИЛЗӨХ бөнжгөр юмны бөнжис бөнжис хөдлөх.

БӨНЖИС: бөнжис бөнжис хийх бөнжгөр юмны **байн** байн хөдлөх.

БӨӨ онгон сршуулж залбирах хүн; *бөө мөргөл;* **бөөгийн дуудлага** (онго урихад шүлэглэн хэлэх үгс); **бөө буух** (онгод орж бүжиглэх).

БӨӨГНӨЛДӨХ олон юмны бөөгнөрөх, цугларах.

БӨӨГНӨРӨЛ бөөгнөрөх үйлийн нэр, цугларал.

БӨӨГНӨРӨХ бөөн болох; хуран цугларах.

БӨӨГНӨРҮҮЛЭХ бөөгнөрөхийн үйлдүүлэх хэв.

БӨӨГНӨХ бөөн болох, хуран цуглах; *гудамжинд олон хүн бөөгнөв; үс ноос бөөгнөх; хонхор хотгорт хог новш бөөгнөх.*

БӨӨГНҮҮЛЭХ бөөгнөхийн үйлдүүлэх хэв; бөөн болгох, хуран цуглуулах.

БӨӨДГӨР жижиг, царай **жавхаа** муутай юм; *бөөдгөр хурга; бөөдгөр дээл.*

БӨӨДИЙ бохир, муухай, бүдүүлэг, заваан; *бөөдий айл; бөөдий хүн.*

БӨӨДИЙДӨХ хэтэрхий бөөдий болох.

БӨӨДИЙЛГӨХ бөөдийхийн үйлдүүлэх хэв.

БӨӨДИЙРЭХ бөөдий болох.

БӨӨДИЙХ бөөдгөр болох, бөөдийж харагдах.

БӨӨДӨГНӨХ бөөдгөр юмны үргэлжлэн хөдлөх байдал.

БӨӨДӨЛЗӨХ бөөдгөр юмны байн байн хөдлөх байдал.

БӨӨЛЖИС бөөлжиж гаргасан зүйл; ☆ **бөөлжис хутгах** (бөөлжмөөр болох); **бөөлжис хүрмээр** (дур гутмаар);

БӨӨЛЖИХ ходоодон доторхи зүйлийг өөрийн эрхгүй амаар огшууран гаргах; *ханиаж байгаад бөөлжив.*

БӨӨЛЖҮҮЛЭХ бөөлжихийн үйлдүүлэх хэв; *бөөлжүүлэх эм.*

БӨӨЛӨХ бөө хүн, онгоноо оршуулах үйл хийх.

БӨӨЛҮҮЛЭХ бөөлөхийн үйлдүүлэх хэв.

БӨӨМ 1. хэсэг; *бөөм ноос; бөөм гурил;* 2. цусны биет бодис; *улаан бөөм; цагаан бөөм;*

БӨӨМНӨЛДӨХ бөөм болох, бөөмнөх.

БӨӨМНӨРӨХ хуран цугларах; *сумдаас ирсэн төлөөлөгчид аймгийн төвд бөөмнөрөв; дээлийн хөвөн бөөмнөрөх.*

БӨӨМНӨРҮҮЛЭХ бөөмнөрөхийн үйлдүүлэх хэв.

БӨӨМНӨХ бөөм болох, бөөмнөх.

БӨӨН 1. бөөмнөсөн хэсэг юм; *бөөн цагаан үүл;* 2. хурсан юм; *бөөн мал тууж явна;* **бөөн бөөн** хорш.; ☆ **бөөн боох** (бөөрөнхий хэлбэртэй шахсан бяслаг хийх); **бөөн од** (долоон одны долоодугаар од).

БӨӨНӨӨР жижиглэхгүй, **их** ихээр, бөөн бөөн хэсгээр; *бөөнөөр худалдах газар.*

БӨӨР 1. нуруу сээрт амьтны шээсийг боловсруулах эрхтэн; *баруун зүүн бөөр;* 2. бөөр байгаа орчим; *бөөр алаг;* ☆ **эрхний бөөр** (эрхний чимэг); **бөөрий нь авах** (хүүхдийг хууран айлгах).

БӨӨРӨГ уулын хажуу этгээдийн дэвсэг хэлбэртэй газар.

БӨӨРӨГЛӨХ I бөөрөг газраар явах.

БӨӨРӨГЛӨХ II 1. чиглэсэн бодлогогүй хүн, хүний саналыг аядан дагалдаж нийлүүлэн явах, бөөрөнхийлэх; 2. амьтны сүүлээ хөдөлгөн шарваганан эрхлэх; *нохой бөөрөглөх.*

БӨӨРӨЛЖГӨНӨ ургамал хар хүрэн өнгөтэй, амттайхан жимс.

БӨӨРӨЛЗГӨНӨ ургамал говь газрын уул хярын хажуу, жалга зав газруудад бутлан ургана; өндөр нь метр орчим, иш үндэсний бүдүүн нь 20 см. орчим, дурс цайвар, гол нь цагаан шар, навч нарийн зузаалаг бөгөөд уртуулаг, үр нь гурван хэлтэстэй, замбагын хэлбэртэй.

БӨӨРӨНХИЙ бөмбөрцөг, бөмбөгөр, бөмбөг мэт хэлбэртэй юм; *дэлхийн бөмбөрцөг бол бөөрөнхий хэлбэртэй,* **бөв бөөрөнхий** (маш бөөрөнхий); **бөөрөнхий үзэл** (дундыг баримтлах үзэл, шийдвэргүй үзэл); **бөөрөнхий үзэлтэн** (дундыг баримтлагч).

БӨӨРӨНХИЙЛӨХ 1. бөөрөнхий болгох; *гурил бөөрөнхийлөх;* 2. шилжсэн эмхлэн цэгцлэх; *ажлаа бөөрөнхийлөх;* 3. шилжсэн шийдвэргүй, бөөрөнхий үзэл гаргах; *бөөрөнхийлөлгүй эрс шулуун хэл!.*

БӨӨРӨНХИЙЛҮҮЛЭХ 1. бөөрөнхийлөхийн үйлдүүлэх хэв; 2. бөөрөнхийлөгдөх.

БӨӨРӨНЦӨГ бяцхан бөмбөрцөг хэлбэртэй юм; *бөөрөнцөг шидэх.*

БӨӨРЦӨГ хэмжих ухааны бие.

БӨӨС хүн амьтны цусыг сорж амьдрах хорхой; **бөөсний хижиг; бөөсний өвчин** (бөөсөөр дамжин халдах өвчин); **нохой бөөс** (цус со-

рогч дэвхэрдэг, жижиг хорхой); **бөөсөн эм** у р г а м а л (нутаг бууц дээр ургадаг, иш навчиндаа үстэй нэг зүйл өвс).

БӨӨСТӨХ бөөс бий болох; *биеэ угааж, хувцсаа цэвэрлэхгүй бохир муухай явбал бөөстөнө.*

БӨӨСТҮҮЛЭХ бөөстөхийн үйлдүүлэх хэв, бөөстөхөд хүргүүлэх.

БӨӨЦГӨР бээцгэр, дорой, яданги; *бөөцгөр өвгөн; бөөцгөр хурга.*

БӨӨЦИЙЛГӨХ бөөцийхийн үйлдүүлэх хэв.

БӨӨЦИЙЛҮҮЛЭХ 1. бөөцийлөхийн үйлдүүлэх хэв; 2. бөөцийлөгдөх.

БӨӨЦИЙЛӨХ амиа бөөрөнхийлөх, асран арчлах; *хүүхэд бөөцийлөх; биеэ бөөцийлөх; амиа бөөцийлөх.*

БӨӨЦИЙХ бөөцгэр болох, бөөцийж харагдах.

БӨӨЦӨГНӨХ бөөцгөр юмны бөөцөг бөөцөг хөдлөх байдал.

БӨӨЦӨЛЗӨХ бөөцгөр юмны бөөцөс бөөцөс хөдлөх байдал.

БӨӨЦРӨХ цөвтнөн хөдлөх; *би зөвхөн гэр зууraa бөөцрөх төдий болжээ.*

БӨӨЧЛӨХ 1. бөө нарын сайн мууг үзэх, тайх тахих; 2. бөөг дууриан үйлдэх.

БӨРТ цагаан, цайвар өнгө зүсэнд оролцсон хар бор толбо; *бөрттэй цагаан; бөрттэй халиун.*

БӨРТГӨР холоос бүдэг, өчүүхэн үзэгдэж байгаа юм; *тэр нэг бөртгөр юм байна.*

БӨРТИЙЛГӨХ бөртийхийн үйлдүүлэх хэв; бөртийхөд хүргүүлэх.

БӨРТИЙХ бөртгөр болох; *алст нэг юм бөртийн харагдав.*

БӨРТӨГНӨХ бөртгөр юмны үргэлжлэн хөдлөх буюу нүдэнд үзэгдэх эсэхийн төдий харагдах; *голын наагуур хүн бөртөгнөн хөдөлж байв.*

БӨРТӨГНҮҮЛЭХ бөртөгнөхийн үйлдүүлэх хэв.

БӨРТӨЛЗӨХ бөртгөр юмны байн байн хөдлөх үзэгдэх байдал.

БӨС хөвөн нэхмэл бараа; *бөс бараа; бөс даавуу; бөс нэхэх; бөс барааны үйлдвэр; бөс барааны тасаг;* **бөс гэр** (майхан).

БӨХ I барилддаг хүн, барилдах биеийн тамирт мэрэгжсэн хүн; *бөх барилдан, морь уралдаж наадам хийв; бөх хүн будүүн өвсөнд* з ү й р; **бөх гарах** (бөх барилдахаар зэхэж засуулч дээр хүрч ирэх); **бөх гоцлох** (өрсөлдөж барилдах учраагүй хүнийг хий давсанд тооцох; бас гоц мөргөх, хий мөргөх, хийлэх ч гэнэ); **бөх давах** (эсэргүүцэл бөхөө дийлж унагаах); **бөх засах** (засуулч харицуцсан бөхөө дагаж барилдуулах); **бөх тавих** (засуулч дээр ирсэн бөхөө барилдуулахаар явуулах); **бөх цоллох** (бөхийн нэр цол дуудаж сонсгох); **бөх шавах** (бөхийн барилдах үед өөрөө хоёр гуян дээрээ алгадах); **бөхийн ам** (угтуул бөхтэй барилдахаар ногдсон бөх; *амын бөх, амандаа унасан бөх аягүй*); **бөх амлах** (а. цолтой бөх, барилдах хүнээ нэр зааж авах; б. бөхийн нэр цол зэргийг барилдахын өмнө өндөр дуугаар дуудаж нийтэд сонсгох); **бөхийн бай** (барилдаж давсан бөхөд олгох шагнал); **бөхийн даваа** (а. барилдах удаа үе; *анхдугаар даваа; нэгийн даваа; долоогийн даваа;* б. дийлж давсан); **бөхийн засуул (ч)** (бөхийг сургах хүн); **бөхийн мэх** (барилдахдаа хэрэглэх арга ов); **бөхийн оноо** (хэн хэнтэй барилдахыг зааж хийсэн данс); **бөхийн цол** (давсны зэргээр бодож тусгайлан олгосон цол начин, заан, арслан, аврага).

БӨХ II тэмээ зэрэг амьтны нуруун дээрх овгор түнтгэр юм; *ширээ бөхтэй ат; нэг бөхтэй тэмээ; бөхтэй үхэр; бөхний өөх*

БӨХ III анжисны малд хөллөх иш; *анжисны бөх.*

БӨХ IV 1. эвдрэх урагдахгүй бат бэх; *бөх гутал;* **амь бөхтэй** (бусниж устахгүй тэсвэрлэдэг); 2. ш и л ж с э н сэтгэл зовиндоггүй; **бөх зүрхтэй** (эмээх зовохыг мэдэхгүй); **нүүр бөхтэй** (ичиж нүүр улайдаггүй, ичихийг мэддэггүй); **ам бөхтэй** (барагтай бол дуугардаггүй, үг цөөнтэй); **бөхтэй шивээ** у р г а м а л (нэвчлэн говь газар ургана; 30 см. хир өндөр, байдал цагаалзайтай адил, үр нарийн хуруу хир иштэй, ишний үзүүрт хандсан үсэн чимэгтэй, доод үзүүрт өөд өлөн шивээ өргөс гарна); **бөх цагаан** у р г а м а л (бат цагааны нам, дүрс хар, хустай адил чанар хатуу, ур үндэс артай нэгэн зүйл мод).

БӨХ V: **өө бөх** овон товон, өө хортон; *өө бөхгүй тэгш газар.*

БӨХГӨР бөгтөр, бөгцгөр, бөхийсөн.

БӨХЖИХ бөх болох; *яс бөхжих; бие бөхжих.*

БӨХЖҮҮЛЭХ бөхжихийн үйлдүүлэх хэв.

БӨХИЙЛГӨХ бөхийхийн үйлдүүлэх хэв.

БӨХИЙХ 1. тонгойх, урагш мэхийх; *бөхийн ёслов; үүдээр бөхийж оров; бичиг бичихдээ үлэмж бөхийж болохгүй;* 2. бууж дагаж өгөх; *харгисын дарлалд бөхийхгүй гэж шүд зуув.*

БӨХЛӨГ хийц бүдүүн боловч бат бэх, эдэлгээ сайтай юм.

БӨХЛӨХ 1. бат бэх болгох; *майхны хэцийг бөхөлж орхив; уяагий нь бөхлөв;* 2. тэсвэрлэх; *чанар сайтай эд эдлэхэд заавал бөхөлдөг юм.*

БӨХЛҮҮЛЭХ бөхлөхийн үйлдүүлэх хэв.

БӨХНӨ а м ь т а н том шар батгана.

БӨХӨВТӨР нилээд бөх.

БӨХӨГНӨХ 1. бөхгөр юмны бөхөг бөхөг хөдлөх байдал; 2. хөнгөмсөглөн бусдын өмнө нахига бөхөгхийн аашлах.

БӨХӨГНҮҮЛЭХ бөхөгнөхийн үйлдүүлэх хэв.

БӨХӨЛЗӨХ 1. бөхгөр юмны бөхөс бөхөс хөдлөх байдал; 2. өөрийгөө доодод үзэж, бялдуучлан явах; *бөхөлзөж нахилзаж явдаг хүн.*

БӨХӨЛЗҮҮЛЭХ бөхөлзөхийн үйлдүүлэх хэв.

БӨХӨН I а м ь т а н гөрөөсний бүлэг, цөл талын ац туурайт хэвдэг амьтан; *бөхөнгийн эвэр; бөхөн агнах хориотой.*

БӨХӨН II з у р х а й сарын зурхайн долоон одны долоодугаар; *бөхөн од.*

БӨХӨӨХ бөхөхийн үйлдүүлэх хэв; бөхөхөд хүргүүлэх.

БӨХӨӨХӨН баахан бөх, нилээд бөх.

БӨХӨР а м ь т а н бөхөнгийн адил, дөрвөн эвэртэй, морин сүүлтэй, хөлдөө тулгууртай нэг зүйл гөрөөс.

БӨХӨРХӨХ бөхдөө эрдэх, бөх гэж давамгайлах, дээрэлхэх.

БӨХӨРХҮҮ бөх шиг шинж байдалтай; *бөхөрхүү хүн.*

БӨХӨСХИЙЛГЭХ бөхөсхийхийн үйлдүүлэх хэв.

БӨХӨСХИЙХ түр зуур бөхийх, нахисхийх.

БӨХӨХ мөхөх, унтрах; *зул бөхөх; гал бөхөх.*

БӨХТЭЙ бөх бүхий юм; *нэг бөхтэй тэмээ; ханан бөхтэй хар буур;* **бөхтэй үхэр** а м ь т а н (бөх мэт өндөр сэрвээтэй, саарал буюу хар алаг зүстэй, чадал ихтэй. Энэтхэг болон зүүн Африк хавиас гаралтай нэг зүйл үхэр).

БРАУНИНГ автомат ажиллагаатай нэг зүйл гар буу.

БРЕЗЕНТ нэг зүйл бүдүүн нэхмэл эд; юм хумыг бороо салхинаас хамгаалах ба нэвчихгүй хувцас цув зэргийг хийнэ; *брезентээр бүтээх.*

БРИГАД 1. хэд хэдэн хороо цэргээс бүрдсэн цэргийн зохион байгуулалт; 2. нэг төрлийн үйлдвэрлэл эрхэлсэн бүлэг; *мал бригад; туслах бригад; саальчны бригад; тариа бригад; урлагийн бригад; бригадаар явах; суртлын бригад; бригадын дарга;* ☆ **социалист хөдөлмөрийн төлөө бригад** (социалист ёсоор хөдөлмөрлөх, амьдрах, сурахын төлөө хамтран ажиллаж байгаа хэсэг хүмүүс); **социалист хөдөлмөрийн бригад** (социалист ёсоор хөдөлмөрлөх, амьдрах, сурах үүргээ биелүүлсэн хэсэг хүмүүс).

БРИЯНГУУ у р г а м а л хөх цэцэгтэй, бутлан ургана; төрөл зүйл 40 орчим, чимэглэлийн зүйлд хэрэглэхийн тулд тарина; мөн эфирийн тосыг гарган авах нь бий, эмнэлэгт хэрэглэнэ.

БРОМ коллодийн бүлэгт багтах бөгөөд хүрэн улаан шүлт бүхий шингэн бодис; эрс үнэртэй, түүний давсуудыг эмнэлэгт ба гэрэл зургийн үйлст хэрэглэдэг язгуур махбод.

БРОНЗ зэс цагаан тугалга хоёрыг нийлүүлэн, будах, чимэглэхэд хэрэглэх нунтаг; *алтан бронз; мөнгөн бронз; бронзоор будах; бронзтой жааз.*

БРУЦЕЛЛЁЗ үе мөч, яс янгинаж шархирах өвчин; хонь, ямаа, үхэр, гахай зэрэг малд тохиолдож хээл хаяулдаг халдварт өвчний нэр; бас хүнд тусна; *бруцеллёзоор өвдсөн мал.*

БУВ хүч нэмэгдүүлэх сул үг; **був буруу** (маш буруу); **був буурал** (маш буурал).

БУВАЙХ бувгар болох, бувайж харагдах.

БУВАЛЗАХ бувгар юмны бувас бувас, бувар бувар хийх.

БУВАР: бувар бувар хийх бувгар юмны хөдлөх.

БУВАС: бувас бувас хийх бувгар юмны байн байн хөдлөх.

БУВАХ амны зоригоор ярих.

БУВГА: бувга бувга хийх бувгар юмны үргэлжлэн хөдлөх.

БУВГАНАХ бувгар юмны бувга бувга хөдлөх.

БУВГАР бавгар, өтгөн их сахалтай; *бувгар сахал.*

БУВРАХ шүдгүй буюу сахал ихтэй амьтны юм идэх.

БУВТНАА бавтнаа, бавтнах дуртай.

БУВТНАХ бавтнах, дэмий ярих.

БУВЧАА бавчаа, дэмий яримтай.

БУВЧИХ дэмий ярих.

БУГ 1. мухар сүсэгтэн, үхсэний хойно хүний сүнс холдож эс чадвал буг болох мэт үздэг ажээ; **буг чөтгөр** хорш.; 2. тээр тойв болон ад үзэгдэх юм; **гэрийн буг болох** (гэрээс үл гарах).

БУГА I амьтан хөхөөр өсдөг, ац туурайт хэвдэг амьтан, эвэр нь олон салаатай; *хандгайтын халтар буга хангинах янзтай* (ардын дуу); *уулын буга үзээд унасан бухаа хаяв зүйр*; **бугын цусан эвэр** (хавар хуучин нь унаж шинээр бүрэлдэн ургаж байгаа эвэр); **бугын ясан эвэр** (эр бугын толгойд ургасан намар цагийн эвэр); **буга хүрээлэх** (зун цагт бугын сүрэглэх); **буга урамдах** (орооныхоо цагт мөөрөн дуугарах).

БУГА II хорин дөрвөн хүүгээр хоёр бугыг хашин наадах тоглоом; *буга тавих.*

БУГАЛГА атгаал; *бугалга чөмөг.*

БУГДАЙЛГАХ бугдайхын үйлдүүлэх хэв.

БУГДАЙХ 1. хүн амьтны бие түрүүлгээ хандан дөрвөн мөчөө атийн атирах; *бугдайж хэвтэх;* 2. үхэхийг цээрлэж ийн нэрлэдэг.

БУГДАЛЗАХ бугдгар юмны байн байн хөдлөх байдал.

БУГДАСХИЙХ түр зуур бугдайх.

БУГДГАНАХ бугдгар юмны үргэлжлэн хөдлөх байдал.

БУГДГАР бугдайсан юм.

БУГЗАЙЛГАХ бугзайхын үйлдүүлэх хэв; бугзайхад хүрүүлэх.

БУГЗАЙХ муу зантай байдал илтэд мэдэгдэх.

БУГЛАА арьсны дотор битүү идээлсэн газар; *буглааг хагалах.*

БУГЛАХ 1. арьсны дотор битүү идээрлэх; *гар дээр гарсан юм буглах;* 2. бугших, нуугдах.

БУГЛУУЛАХ буглахын үйлдүүлэх хэв, бугшуулах.

БУГСАХ 1. хилэгнэж дуу гарахгүй болох, битүү уурлах; 2. бага хүүхдийн гөрлөх.

БУГСУУЛАХ бугсахын үйлдүүлэх хэв.

БУГУЙ хүний богт чөмөгний нарийн үзүүрийн тус газар.

БУГУЙВЧ 1. гарын бугуйд зүүх гоёл; *алтан бугуйвч;* 2. бугуйдаа өмсөх хувцас; *устэй бугуйвч.*

БУГУЙЛ адуу малыг барих үзүүрт нь гоцоо гаргасан урт оосор; *бугуйл хаях; бугуйлаар морь барих.*

БУГУЙЛДАХ морь малыг бугуйлаар барих; *бугуйлддаг хүн.*

БУГУЙЛДУУЛАХ 1. бугуйлдахын үйлдүүлэх хэв; 2. бугуйлдагдах.

БУГУЙЛЧ бугуйл хаяхдаа чадамгай хүн.

БУГШИХ 1. буглах битүү идээлэх; 2. хорон санаа битүү өвөрлөн хадгалах; 3. хэрэг явдлын битүүлэг нуугдмал байх; 4. дармал, хадгалмал; *бугшсан хулгай.*

БУГШМАЛ бугших үйлийн нэр; *бугшмал хэрэг; бугшмал хөрөнгө.*

БУГШУУЛАХ бугшихын үйлдүүлэх хэв; бугшихад хүрүүлэх.

БУД Лхагва.

БУДАА 1. үр тариа; **будаа тариа; будаа гурил** хорш.; *гурвалжин будаа; шар будаа; болсон будаа; цагаан будаа; хар будаа; хүүхдийн будаа; хогсмол будаа; чангаамал будаа;* 2. хоол; *будаа ид!; будаа зоогло; будаатай шөл; будаатай хуурга;* ☆ **бусдаас будаа идэх** (бусдын юмыг ашиглан жавших); **хүний амаар будаа идэх** (бусдын үгийг аядан дагалдах).

БУДААЛАХ 1. хооллох; 2. дайлах, цайлах; 3. бусдын юмыг хайрлахгүй; *тэр тэдний хөрөнгийг будаалж гүйцэв.*

БУДААЛГА дайллага, цайллага; *будаалга хийх; будаалганд очих.*

БУДААЛУУЛАХ 1. будаалахын үйлдүүлэх хэв. 2 .будаалагдах.

БУДААЧ будахдаа чадамгай хүн; *будаач будаач гэхээр сахлаа будах.*

БУДАГ юм будах, зураг зурахад хэрэглэх зүйл; *тосон будаг; усан будаг; будаг түрхэх; будаг гаргах; будаг нийлүүлэх; нүүрийн будаг; үруулын будаг.*

БУДАГДАХ будахын үйлдэгдэх хэв.

БУДАГЛАХ будах.

БУДАГЧ будахад чадамгай.

БУДАЛТ будсан байдал; *будалт нь сайн.*

БУДАН усны уур хуралдсаны улмаас агаарын хий дээд талаараа тунгалаг, доод талаараа бүдэг бүрхэг болох; **будан татах** (манан татах); **будан үүл** (дээш дэгдэж нимгэн болсон үүл); **будан тунах** (будан доошлох); **будан дэгжих** (будан дээшлэх); **будан сөхөх** (будан сарних).

БУДАНГУЙ бядуу мунхаг, харанхуй бүдүүлэг; *харанхуй буданғуй; шашны буданғуй үзэл.*

БУДАНГУЙРАХ будангуй болох.

БУДАНГУЙРУУЛАХ будангуйрахын үйлдүүлэх хэв.

БУДАНТАХ будан суух, будан бий болох.

БУДАНТУУЛАХ будантахын үйлдүүлэх хэв.

БУДАХ 1. будаг түрхэх; *ногооноор будах; нүүрээ будах; тоно будах; даавуу будах; хумсаа будах.* 2. шилжсэн үймэн айман хөдлөх; *хүүхэд багачууд бужигнан наадаж байв; цуугилдан бужигнах хэрэг алга.*

БУДАЦ будах үйлийн явц; *будац муу байна.*

БУДДИЗМ Энэтхэг, Хятад, Монгол зэрэг дорно зүгийн оронд дэлгэрсэн шашин.

БУДЛИАН 1. самуурал; *будлиан хутгах; бөөн будлиан болов;* 2. мөргөлдөөн, маргалдаан, тэмцэлдээн; *будлиан болох; будлианы эзэн; хилийн будлиан; будлиан өдүүлэгч.*

БУДЛИАНГҮЙ самуурах, будлих явдал байхгүй; *тэр будлианғуй хүн.*

БУДЛИАНТАЙ самууралтай, ярших төвөг ихтэй, будлимаар юм.

БУДЛИАНТАХ будлиан болох, будлих.

БУДЛИАНТУУЛАХ будлиантахын үйлдүүлэх хэв; *данс будлиантуулах.*

БУДЛИУЛАХ будлихын үйлдүүлэх хэв, будлиан болгох.

БУДЛИУН самгардамгай, эндүүрч буруу хийдэг, будилдаг, сэргэлэн биш, мохоо; *будлиун амьтан; будлиун хүнээр ажил хийлгэснээс байсан нь дээр.*

БУДЛИХ самгардах, эндүүрэх, буруу болгох; *үчры нь олохгүй, толгой нь эргэж будлин суув; данс будлих; би багшийн өмнө будлих шахав.*

БУДМАЛ будсан юм; *будмал бөс; будмал хээ.*

БУДРАХ цас борооны бяцхан бурганан орж манарах, цайрах, бурганах; *цас бударч байна; тэнгэр будрах.*

БУДРУУ адруу будруу.

БУДРУУЛАХ будрахын үйлдүүлэх хэв.

БУДУУЛАХ 1. будахын үйлдүүлэх хэв; 2. будагдах.

БУЖГА шувууны сөдний дараа ургасан өрвөлөг.

БУЖГИР атиран гархилсан, аржгар буржгар юм; *бужгир үстэй хүүхэд; бужгар арьс; бужгир болгох.*

БУЖГИРТАХ бужгир тогтох, бужгир үзэгдэх.

БУЖИГНААН үймээн шуугиан, хөл хөдөлгөөн; *бужигнаантай гудамж.*

БУЖИГНАХ 1. хийсч хөдлөх; *тоос бужигнах;* 2. шилжсэн үймэн айман хөдлөх; *хүүхэд багачууд бужигнан наадаж байв; цуугилдан бужигнах хэрэг алга.*

БУЖИГНУУЛАХ 1. бужигнахын үйлдүүлэх хэв; 2. үймүүлэх, бусниулах, түйвээх.

БУЖИЙЛГАХ бужийхын үйлдүүлэх хэв.

БУЖИЙХ бужгир болох, бужийж харагдах.

БУЗАМГАЙ бузгай.

БУЗАМГАЙРАХ бузамгай байдал гаргах, бузамгай болох.

БУЗАМГАЙРХАХ бузгайрхах.

БУЗАР I 1. бохир буртаг болсон, хир буртагтай, ариун цэвэр биш; **бузар булай; бузар буртаг; бузар муухай** хор ш.; 2. жигшүүртэй, үзэшгүй муухай, залихай; *бузар хэрэг үйлдсэн этгээдийг олон түмэн уурсан занав; бузар явдал.*

БУЗАР II маш, нэн; *бузар сайн; бузар муу; бузар олон; бузар тарган.*

БУЗАРЛАЛ бузарлан гутаах үйлийн нэр.

БУЗАРЛАХ 1. бузар болгох; 2. гутаах; *нэр бузарлах;* 3. буседад хүсэн горилж хэлсэн үг бүтэмжгүй болох; *ам бузарлах.*

БУЗАРЛУУЛАХ 1. бузарлахын үйлдүүлэх хэв; 2. бузарлагдах.

БУЗАРТАЙ бузар бүхий, шившигтэй, муухай; *бузартай явдал.*

БУЗАРТАХ бузар болох, гутах.

БУЗАРТУУЛАХ бузартахын үйлдүүлэх хэв.

БУЗГАЙ баахан сайн, ашгүй, овоо, зэгсэн; *бузгай дулаан өдөр; бие бузгай байна; бузгай морь; бузгай тарган.*

БУЗГАЙРАХ бузгай царай гаргах.

БУЗГАЙРХАХ 1. дээрэнгүй зан гарган аашлах; 2. сайн хүн болох гэж оролдох.

БУЙ бий, бий бүхэн, -тай; *надад юм бий; манайд сайхан зураг буй.*

БУЙВОЛ амьтан нэг зүйл үхэр, зэрлэг тэжээмэл хоёр янз бий; тэжээмэл буйволын арьс үнэтэй **бөгөөд** сүүний тослог нь их болно.

БУЙД бөглүү, тасархай, алс хол; *буйд хязгаар; буйд нутаг; хүн амьтангүй буйд газар;* **зэлүүд буйд** хорш..

БУЙДАХ шүүрдэх; *хог буйдах.*

БУЙДУУР газар шүүрдэх шүүр.

БУЙЛ I тэмээний хамарт хийж бурантаг уях мод; **буйлан товх** (буйлын үзүүрт угласан шир).

БУЙЛ II бүйл.

БУЙЛАХ I тэмээ уянгалан дуугарах; *ботго буйлж байна.*

БУЙЛАХ II тэжээсэн нохой шувуу зэрэг амьтан бусад амьтныг барьж сурах; *бүргэд буйлах; харцага буйлах.*

БУЙЛАХ III дарсан юмны ааг хүч улам нэмэгдэх; *жимс буйлах; архи буйлах.*

БУЙЛЛАХ тэмээний хамарт буйл хийх; *тэмээ буйллах.*

БУЙЛМАЛ буйлах үйлийн нэр, буйлсан юм; *буйлмал бүргэд; буйлмал архи.*

БУЙЛС ургамал хальс хүрэн,үр нь зуувай бөөрөнхий, говь хангай нутгийн уулархаг, чулуутай газар ургадаг нэг зүйл бутархаг ургамал; *буйлсны сүү.*

БУЙЛУУЛАХ буйлах I II III-ын үйлдүүлэх хэв; *ингэ буйлуулах; харцгай буйлуулах; дарс буйлуулах.*

БУЙЛУУЛМАЛ буйлуулсан зүйл; *буйлуулмал дарс.*

БУЙМАН хөзрийн зүрхэн хэлбэртэй зураг; *буйман улаан; бундан ч гэнэ.*

БУЙР I эр халиу.

БУЙР II 1. байх орших газар; *гэрийн буйр; буйр засах; зөвхөн буйр нь үлджээ; буйраа эзэл!;* 2. мөр, ором; *шатсан байшингийн буйр дээр; буйр нь дөнгөж мэдэгдэж байна.*

БУЙР III ул, суурь, хашир, доги, хянуур, болгоомжтой; *буйртай хүн; буйртай суурьтай явах хэрэгтэй; буйр сууриа бүү алд!.*

БУЙРАЛХАХ буйртай байдал гаргах, хашир байдал гаргах .

БУЙРГҮЙ суурь муутай, хөнгөн хуумгай.

БУЙРЛАХ буйр гаргах, уллах, хашир байдал гаргах.

БУЙРТАЙ суурь сайтай, хашир, болгоомжтой; *буйртай хүн.*

БУЛ I 1. тэрэгний дугуйн төвийн бүдүүн хэсэг; *тэрэгний бул;* 2. өнхрүүлж юмыг няцлах, дарах хүнд зэвсэг; *индүү бул;* ☆ **бул хар чулуу** (ургаа том чулуу); **бул хар чулуу шиг** (хөнгөн хөдөлгөөнгүйн учир тотгор болох юм).

БУЛ II овоолсон цогцолсон өвс; *нэг бул өвс.*

БУЛААЛГАХ 1. булаахын үйлдүүлэх хэв. 2. булаагдах.

БУЛААЛДААН мөргөлдөөн, тэмцэлдээн; *хэний зөв, хэний буруу болохыг булаалдан ярилцав; эд агуурс булаалдан тэмцэв.*

БУЛААЛДАХ булаахын үйлдэлдэх хэв; тэмцэлдэх, маргалдах, булаацалдах; *тэмцэн булаалдах; үг булаалдах.*

БУЛААХ бусдын юмыг эзэрхэн авах; *гараас булаан авчээ; ноцолдож байгаад булаан авав;* **булаан эзлэх** (хүчээр эзлэх); **дээрэмдэн булаах** (хүч түрэн дээрэмдэж авах); **дур булаах** (сонирхолтойд нь шимтэх).

БУЛААЦАЛДАХ 1. булаалдах, булаан авах; **барил булаацалдах** (барилдахад ашигтай барилыг олохын төлөө тэмцэлдэх); **цэц булаацалдах** (хэл амаар бие биеэсээ давахыг хичээж харилцан маргалдах).

БУЛАГ I 1. газар дороос оргилон гарах ус; *булгийн хүйтэн усаар нүүрээ угаав;* 2. шилжсэн эх үүсвэр; **эх булаг** хорш.; **эрдмийн эх булаг** (эрдмийн эх, үүсвэр).

БУЛАГ II чихнээс идээ гоожих өвчин; *булаг гооздог хүүхэд; чихний булаг.*

БУЛАГ III алаг, зарим амьтны хөл ба туурайн өнгө цагаан; *хөл булаг морь; туурай булаг луус;* **алаг булаг** х о р ш.: *тээг тээг явдалтай, тэхийн сайран гуталтай, алаг булаг дахтай алтан уурга чирээстэй* о н ь с о г о.

БУЛАГДАХ 1. булахын үйлдэгдэх хэв; 2. хаагдаж дарагдах; *нэр алдар нь булаагдах.*

БУЛАГНАХ 1. булан болгох, хагаслах; *цай булагнах;* 2. мэдэгдэлгүй нуун далдалж явах; *нам нийлж булагнах.*

БУЛАГТАХ 1. булаг өвчин тохиолдох; *чих булагтах;* 2. алагтах; **алагтах булагтах** х о р ш..

БУЛАЙ I маш, мөн; *булай сайн; булай муу.*

БУЛАЙ II жигшмээр, муухай; **бузар булай** х о р ш.; *нүдний булай болох; булай амьтан; булай хэрэг.*

БУЛАН I 1. өнцөг; *байшингийн булан; ширээний булан;* **өнцөг булан бүрд** (газар бүр); *буланд шахаж байгаад барив;* ☆ **улаан булан** (соёл гэгээрлийн ажил явуулах албан газар, байр); 2. тал, хэлтэрхий; *боовны булан; талхны булан; булан цай.*

БУЛАН II ямар нэг юм руу тохойрон орсон газар; *далайн булан; Хужир булан;* **булан тохой** х о р ш..

БУЛАНГИР булингар.

БУЛАНГИРТАХ булингартай болох.

БУЛАР хөвсгөр зөөлөн хөрс шороотой газар.

БУЛАРХАЙ зөөлөн хөрс; *булархай хөрс.*

БУЛАХ 1. үүрмэг юм дээрээс нь асган битүүлж дарах; *шороонд булах; газар булах; цасаар булах;* 2. ш и л ж с э н дарах далдлах; *хэргээ булахын тул элдэвлэж үзэж байна.*

БУЛБАГАНАХ булбагар юмны булбага булбага хөдлөх байдал.

БУЛБАГАР улбагар, сул дорой.

БУЛБАЙХ булбагар болох, бүлбайж харагдах.

БУЛБАЛЗАХ булбагар юмны булбас булбас хөдлөх байдал.

БУЛБАРАЙ 1. зөөлөн, хатуу болоогүй; 2. өсч торниж гүйцээгүй, балчир; *булбарай хүүхэд; булбарай биетэй.*

БУЛБАРАЙДАХ балчирдах, томоогүйдэх.

БУЛБАСХИЙХ булбагар юмны түр зуур булбалзах.

БУЛГА I а м ь т а н үс зохистой зөөлөн бөгөөд ихэнхдээ бор, хүрэн, хар; зарим нь сортой, арьс нь үнэтэй, бие багавтар амьтан; *булган дахын чинь хариуд бутарсан улсыг чинь цуглуулж өгье; бутан дээр булган малгай* о н ь с о г о; **булганы идээ** у р г а м а л (өнгө улаан, амт хүчтэй жимс); **булган таваг** у р г а м а л (навч булганы тавагтай адил бөгөөд жижиг, хээр ургана).

БУЛГА II: **булга татах, булга цохих,** булгалан мултлах.

БУЛГАЛАХ булгарах; *үеэр нь булгалах.*

БУЛГАЛУУЛАХ булаглахын үйлдүүлэх хэв; булгалагдах; *том нарсыг үндсээр нь булгалуулах.*

БУЛГАН булга.

БУЛГАРАХ үе уулзуураар буюу үндэс ёзоороор мултрах, салах, ховхрох; *хуруу булгарах; мод ёзоороороо булгарчээ.*

БУЛГАРХАЙ 1. нэгэнт булгарсан юм; *булгархай хуруу;* 2. юмны булгарсан хэсэг; *баганын булгархай.*

БУЛГАХ хатуу юмыг зажилж чадахгүй амнаас буцааж гаргах.

БУЛГИЛАХ долгилох, цохилох; *зүрх булгилах.*

БУЛГИУЛАХ 1. булгихын үйлдүүлэх хэв; *даага булгиулах;* 2. булгигдах.

БУЛГИХ 1. тонгорцоглон харайлах; *эмнэг морь унамагц булгив; булгидаг морь;* 2. тогтворгүй холборон унах; *усанд хөвж явсан гуалин дээр мордож орхитол булгиж орхижээ.*

БУЛДААХ булдах II-ын үйлдүүлэх хэв.

БУЛДАХ I 1. булаар өнхрүүлэн няцлах, толийлгох; *тариа булдах; торго булдах;* 2. бул газардах.

БУЛДАХ II наалдах, шингэх; *шавар булдах; тос булдах.*

БУЛДРУУ 1. булуу, булцруу; *модны булдруу;* 2. адруу будруу; *булдруутай газар;* 3. харвисын дотоодод цогцлон тогтсон бэржгэр мах.

БУЛДРУУТАХ булдруу бүхий болох, булдруу тогтох.

БУЛДУУЛАХ 1. булдахын үйлдүүлэх хэв; 2. булдагдах.

БУЛЖИХ үе гишүү гажиж гэмтэх; *мөр булжих ;шагаа булжих.*

БУЛЖУУЛАХ 1. булжихын үйлдүүлэх хэв; 2. булжигдах.

БУЛЗААРАХ зайчих, булзах; *хэлснээ булзаарах; хийснээ булзаарах.*

БУЛЗААРУУЛАХ булзаарахын үйлдүүлэх хэв, бусад юмаар шалтаж буцахыг оролдох; *өөрийн тухай ярихад бусад юм ярьж булзаарууллахыг оролдох.*

БУЛЗААЧ булзаж зайлж сурсан.

БУЛЗАМХАЙ булздаг зантай.

БУЛЗАХ бултах, зайлах, займрах, буцах; *бие булзах хэрэггүй.*

БУЛИА хүчирхэг, тэнхээлэг, лут биерхэг; *булиа эр; булиа том.*

БУЛИАЛДАХ булаалдах, булаацалдах.

БУЛИАХ булаах.

БУЛИГААР үхэр адууны ширийг боловсруулан, ханан хээ гаргаж хийсэн эд; *булигаар богц; булигаар гөлөм; булигаарын завод.*

БУЛИГААРЛАХ булигаараар бүрэх; *ташуурын бариулыг булигаарлах.*

БУЛИГДАХ булихын үйлдэгдэх хэв; дийлэгдэх.

БУЛИЛАХ 1. туйлах, дургих; *хөрөнгөөрөө булилж яваа хүн;* 2. залилах, булхайлах; *булилж булхай зан битгий гарга!;* 3. түрэмгийлэх, гөрлөх; *эрдэж булилах муу.*

БУЛИМГАЙ булиа хүчтэй; *булимгай хүн.*

БУЛИНГАР 1. шингэн зүйлийн дотор хөвж яваа өчүүхэн хэсгүүд; *усанд булингар суув; булингар нь хөдлөх;* 2. шилжсэн тунгалаг биш; *нүд нь булингартай байв;* 3. цус холилдсон; *булингартай цэр.*

БУЛИНГАРТАЙ булингар бүхий; *эх нь булингартай бол адаг нь булингартай.*

БУЛИНГАРТАХ булингартай болох.

БУЛИНГАРТУУЛАХ булингартахын үйлдүүлэх хэв; *ус булингартуулах.*

БУЛИХ дийлэх, давах, давамгайлах.

БУЛРАХ 1. хүнд хүчир ажлаас болж бие нозоорон эвгүйрэх; *бие булрах;* 2. морь малын хөл ядарч туйлдан доголох; *морь булрах.*

БУЛРУУЛАХ булрахын үйлдүүлэх хэв.

БУЛТ нийтээр, цугаар, цөм, бүгд; *та нар булт явах болно; бултын нь авах уу?.*

БУЛТААРАА нийтээрээ, цөмөөрөө, цугаараа, бүгдээрээ; *нэр дурдсан хүмүүс бултаараа ирсэн.*

БУЛТААЧ зайлсхийх зантай.

БУЛТАГЧ бултах этгээд.

БУЛТАЙЛГАХ бултахын үйлдүүлэх хэв; *хүний өөдөөс хэлээ булгайлгах муухай.*

БУЛТАЙХ бултгар, бөөрөнхий юмны цухуйж гарах; *хулгана нүхнийхээ амаар бултайж байна; бутны цаанаас бултайх.*

БУЛТАЛЗАХ бултгар юмны бултас бултас хийх; *хулгана нүхний амсраар бултлзаж байв.*

БУЛТАЛЗУУЛАХ бултлзахын үйлдүүлэх хэв.

БУЛТАМТГАЙ бултдаг зантай; *оготно бултамтгай амьтан.*

БУЛТАМХАЙ бултамтгай.

БУЛТАС: бултас бултас хийх бултгар юмны байн байн хөдлөх.

БУЛТАСХИЙХ 1. юмны түр зуур булгайх; 2. зайлсхийх.

БУЛТАХ 1. зугадах, хажуу тийш холбирон буруулах; *гүйгээд барьж авах гэтэл бултан зайлав;* 2. шилжсэн бие зайлах, зайлсхийх, буруулах, *холбогдсон хэргээс бултаж гарахыг эрмэлзжээ.*

БУЛТГА: бултга бултга хийх бултгар юмны үргэлжлэн хөдлөх.

БУЛТГАНАХ бултгар юмны бултга бултга хийх; *үүдний завсраар хүүхдийн нүүр бултганаж байв.*

БУЛТГАНУУЛАХ бултганахын үйлдүүлэх хэв.

БУЛТГАР бяцхан амьтны бие буюу толгой хоншоор мэт бөөрөнхийдүү юмыг өхөөрдөн нэрлэх нэр, *булгар оготно.*

БУЛТРАХ үүгээр түүгээр чөлөө гарган аливаа юмнаас зайлсхийн явах.

БУЛТУУЛАХ бултахын үйлдүүлэх хэв; *хурга ялгаж байгаад нэг ишиг бултуулаад гаргачих шахав.*

БУЛУУ 1. чөмөг ясны үзүүрийн бүдүүн хэсэг; *чөмөгний булуу; даахгүй нохой булуу хураах* зүйр; 2. бөлцгөр болсон; *булуу болтол*

үйлах; булуу болтол хавдах; 3 .балаг, тээр тойв болох юм; *толгойдоо булуу хураах хэрэггүй; буcдын булууг өөртөө бүү авчир!*

БУЛУУЛАХ 1. булахын үйлдүүлэх хэв; 2. булагдах.

БУЛХАЙ ямар нэгэн үйл явдалд гарах шудрага биш байдал; *булхай хийхгүй тоглоё; булхай буруу ханддаг.*

БУЛХАЙЛАХ булхайтай зан байдал гаргах.

БУЛХАЙЛГАХ булхайхын үйлдүүлэх хэв; булхгар болгох.

БУЛХАЙХ булхгар болох, булхайж харагдах.

БУЛХАЙЦАХ булхайч байдал гаргах, башир арга заль хэрэглэх.

БУЛХАЙЧ булхайцдаг зантай.

БУЛХАЛЗАХ булхгар юмны булхас булхас хийх; *хөхүүртэй айраг булхалзаж байв.*

БУЛХАС: булхас булхас хийх булхгар юмны байн байн хөдлөх.

БУЛХАХ 1. зайлан угаах; *гараа булхах; амаа булхах;* 2. алт, мөнгө, тугалга зэргээр зайлах; *тогоогоо тугалгаар булхах;* 3. хангалуун байх; *эд мөнгөөр булхаж байгаа хүн дээ.*

БУЛХГА: булхга булхга хийх булхгар юмны үргэлжлэн хөдлөх.

БУЛХГАНАХ булхгар юмны булхга булхга хийх.

БУЛХГАР зөөлөн, нялцгай, улхгар буюу бөөрөнхийвтөр, барихад бултан хөдлөхүйц юм.

БУЛХДАС бие гар нүүр угаасан ус.

БУЛХУУЛАХ 1. булхахын үйлдүүлэх хэв; 2. булхагдах.

БУЛЦАЙЛГАХ булцайхын үйлдүүлэх хэв, булцгар болгох.

БУЛЦАЙХ булцгар болох, булцайж харагдах.

БУЛЦАЛЗАХ булцгар юмны булцга булцга хөдлөх байдал.

БУЛЦГАНАХ булцгар юмны булцас булцас хөдлөх байдал.

БУЛЦГАР бондгор бумбагар хэлбэртэй юм; *булцгар тарган хүүхэд; булцгар хоёр хацар нь улаан.*

БУЛЧИН 1. агших сунах чадалтай, нэхмэлээр бүтсэн, хүн амьтны хөдөлгөөнт эрхтэн; *гарын булчин; зүрхний булчин; хөлийн булчин;* 2. шөрвөс холилдсон мах; *булчин мах;* 3. чийрэг, шөрвөс сайтай; *булчинтай залуу.*

БУЛЧИРХАЙ бие махбодид хэрэгтэй бодисыг боловсруулах буюу эсвэл хэрэггүй бодисыг гадагш ялган гаргах эрхтэн; *шүлсний булчирхай; дотор шүргэх булчирхай; бамбай булчирхай;* **булчирхай сочих** (булчирхай томрон хавдах өвчин); **өөх ч биш, булчирхай ч биш** з ү й р. (хоёрын хооронд).

БУЛЧИРХАЙТАХ булчирхайн өвчин тохиох.

БУЛШ 1. үхсэн хүний хүүр оршуулсан газар; 2. дарж булсан юм; **булш дарш** х о р ш.; *шинжилгээнийхэн булш малтаж үзэв; дөрвөлжин булш;* **хэрэгсүүр булш** х о р ш..

БУЛШЛАГЧ ямар нэг юмыг үхүүлэн сөнөөгч; ***пролетари нар бол капитализмыг булшлагч.***

БУЛШЛАХ булш болгох, даршлах, *хүүр булшлах.*

БУЛШЛУУЛАХ 1. булшлахын үйлдүүлэх хэв; 2. булшлагдах.

БУЛЬДАХ юмыг элбэгжүүгээр хэрэглэх; *сүүгээр бульдсан цай; гурилаар бульдсан хоол; торгоор бульдаж явдаг хүн .*

БУЛЬХАЙ гүтгэлэг, гөрдлөг, зальхай мэлзлэг.

БУЛЬХАЙЛАХ гөрдөх, гүтгэх, мэлзэх.

БУЛЬХАЙЦАХ бульхайч зан гаргах.

БУЛЬХАЙЧ гүтгээч, гөрдөөч, мэлзээч.

БУМ арван түм буюу зуун мянга; *түм буман хүн; бумт жолооч нарт баяр хүргэв.*

БУМБА I 1. өндөр хүзүүтэй бариулгүй сав; **бурхангүй газар бумба галзуурах** (юм мэдэх хүнгүй газар юм мэдэхгүй хүн сагсуурах); 2. доторхи хий сийрэгжүүлэн цус зэргийг соруулах жижиг сав; *бумба тавих.*

БУМБА II бунхан.

БУМБАГАНАХ бумбагар юмны үргэлжлэн хөдлөх байдал.

БУМБАГАР бөөрөнхийдүү хэлбэртэй юм; *бумбагар хацар; бумбагар сав.*

БУМБАДАХ 1. доторхи хий сийрэгжиж агаарын даралт хүндэрснээс авсаар салахгүй болох; 2. бумба тавих бумбаар соруулах.

БУМБАДУУЛАХ 1. бумбадахын үйлдүүлэх хэв; 2. бумбадагдах.

БУМБАЙЛГАХ бумбайхын үйлдүүлэх хэв, бумбагар болгох.

БУМБАЙХ бумбагар болох, бумбайж харагдах.

БУМБАЛЗАХ бумбагар юмны байн байн хөдлөх байдал; бумбас бумбас хийх.

БУНДАЙЛГАХ бундайхын үйлдүүлэх хэв, бундгар болгох.

БУНДАЙХ бундгар болох, бундайж харагдах; *бундайсан хөөрхөн хацартай хүүхэд.*

БУНДАЛЗАХ бундгар юмны байн байн хөдлөх байдал, бундас бундас хийх.

БУНДАН буйман.

БУНДГАНАХ бундгар юмны үргэлжлэн хөдлөх байдал, бундга бундга хийх.

БУНДГАР бондгор бөөрөнхийдүү хэлбэртэй жижгэвтэр юм; *бундгар хацар; бундгар сав.*

БУНДУЙ бие жижиг махлаг тарган хүүхэд.

БУНДУУ юманд гарсан ур ,бундгар юм; *тэр хүний шилэн хүзүүн дээр бундуу ургасан байна; бундуут хээр морь.*

БУНХАН нас барсан хүний шарил чандрыг агуулсан орон барилга; *Сүхбаатарын бунхан.*

БУНЦАЙХ бунцгар болох, мунцайх.

БУНЦГАР бонцгор, мунцгар хэлбэртэй юм.

БУНЪАА у р г а м а л гоёл чимэглэлд хэрэглэхээр тарьж ургуулдаг олон наст цэцэгт ургамлын нэг зүйл.

БУР I 1. замаг; 2. харанхуй.

БУР II: **бур бур** шингэн юмны буцлах зэрэгт гарах дуу; *бур бур хийх.*

БУРАА I хавирганы толгой тал; *хавирганы бураа.*

БУРАА II уул, хээр газар хүй хүйгээр ургасан мод бут; *уулын бураа;* зарим нутагт бургасыг бураа гэдэг.

БУРАМ зэгснээс гардаг, хар бор өнгөтэй, чихэр амттай зүйл; *хар бурам; бор бурам;* **шар бурам** (чихрийн шаар); **цагаан бурам** (цасан чихэр); **татмал бурам** (гурил тостой чанасан бурам); **чихэр бурам** х о р ш . .

БУРАМЛАГ у р г а м а л хэлбэр жүржийн адил, гуа мэт том нэг зүйл жимс.

БУРАНГУЙ шудрага биш; зэхий муу явдалтай; *бурангуй хүн; урьдын бурангуй түшмэдийн жигшүүрт явдал; бурангуйд шудрагагүй.*

БУРАНГУЙЛАХ бурангуйгаар хяхах.

БУРАНТАГ тэмээний буйлнаас уяж хөтлөх нарийн оосор; *бурантгаа иддэг тэмээ.*

БУРАНТАГЛАХ тэмээний буйланд бурантаг уях; *тэмээгээ бурантаглаж байв.*

БУРАНТАГЛУУЛАХ 1. бурантаглахын үйлдүүлэх хэв; 2. бурантаглагдах.

БУРАХ 1. хөөсрөх; *хөөс бурж байна;* 2. ш и л ж с э н дэмий олон үг ярих; *ямар их бурдаг амьтан бэ?.*

БУРГААС бургас.

БУРГАНА у р г а м а л нэгэн зүйлийн харгана, бяцхан, цэцэг шар.

БУРГАНАХ 1. бургах; 2. орж буй цас салхинд хөөгдөн лавсах; *цас бурганах.*

БУРГАС 1. у р г а м а л гулзгар уяхан мөчиртэй, нарийн навчтай, бутлаг ургах мод; *бургасан хана; бургасны мөчир;* 2. бургасан ой шугуй; *бургасан дотроос гөрөөс гарч ирэв;* **бургасны гөлөг** (бургасны навч дэлгэрэн ургахын өмнөхөн гарах бяцхан ором).

БУРГАХ цас бороо нарийн ширхгээр бяц хан орох; *тэнгэр бургах.*

БУРГИЛАХ 1. оргилон ундрах; *бургилан байгаа булгийн хүйтэн ус;* 2. ширүүн буцлах; *цай бургилж байхад нь гаргав;* 3. бургилдах.

БУРГИЛДАХ тохигүй байдалтайгаар үймэлдэн орших; *бургилдан үймсэн айл.*

БУРГИЛУУЛАХ бургилахын үйлдүүлэх хэв.

БУРГИУЛАХ бургихын үйлдүүлэх хэв.

БУРГИХ оргилон бужигнах; *яндангаар утаа бургиж байна; хивс гүвэхэд тоос бургив.*

БУРГУЙ 1. юмны нүх сүвийг цэвэрлэх хөндийлөх хэрэгсэл; *гансны бургуй;* 2. шээс хаагдахад гаргах хэрэгсэл; *шээсний бургуй;* 3. гэдэсний доторхи өтгөнийг цэвэрлэх хэрэгсэл; *бургуй тавих.*

БУРГУЙДАХ бургуйгаар цэвэрлэх; *ганс бургуйдах.*

БУРГУЙДУУЛАХ 1. бургуйдахын үйлдүүлэх хэв; 2. бургуйдагдах.

БУРДХИЙЛГЭХ 1. бурдхийхийн үйлдүүлэх хэв; 2. түргэн буцалгах:

БУРДХИЙХ түргэн буцлах, оргих.

БУРЖГАР бужгар, аржгар.

БУРЖИЙЛГАХ буржийхын үйлдүүлэх хэв; *үсээ буржийлгах.*

БУРЖИЙХ буржгар болох, буржийж харагдах.

БУРЖУЙ буржуйлиг ангид хамаарагдах дарлагч этгээд.

БУРЖУЙЛИГ үйлдвэрлэлийн хэрэгслийг хувьдаа эзэмшиж, нэмүү өртгийг завшин, ажилчин ангийн хүч хөдөлмөрийг сорон мөлжих аргаар баяждаг капиталист нийгэмлэгийн ноёлогч анги; **буржуйлиг хувьсгал** (феодалын нийгэмлэгийн байгуулал ба хамжлагат ёс, помещик ангийн ноёрхлын эсрэг гэмцэж, эцэстээ нөгөө дарлагч анги болох буржуйлигууд засгийн эрх булаан авах хувьсгал).

БУРЗАЙЛГАХ бурзайхын үйлдүүлэх хэв.

БУРЗАЙХ бурзгар болох, бурзайж харагдах; *энэ монсноос мойл жимс бурзайтал ургажээ; голын захаар хужир бурзайж байв.*

БУРЗАН 1. үлээвэр хөгжмийн аманд зуух буюу уруулд тулгах хэсэг нь; *бүрээний бурзан;* 2. гансны соруулын аманд зуух хэсэг; *соруул бурзангаараа хугарав.*

БУРЗГАР бөөрөнхийдүү буюу бяцхан юмны багсайж байгаа үүр бөм юм; *бурзгар жимс; бурзгар шороо.*

БУРИАГУУЛ у р г а м а л ургаж байгаа үедээ мөчир нь усархаг, навч нь гонзгойвтор, нэг зүйл бутархаг ургамал, зарим газар далан хальс, шүүр, уриагуур ч гэж нэрлэдэг.

БУРИАД Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Өөртөө засах Бүгд Найрамдах Буриад Улсын олонхи хүн ам болон Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зарим нутагт байгаа хүн амын нэр; *Ага буриад; Хорь буриад; Шинэхээний буриад.*

БУРИВАА хээнгэшиж байгаа юманд тогтсон толбо буюу бичил мөөг.

БУРИМАГ буримдахдаа чадмаг, зоримог; *буримаг хүн.*

БУРИМДАХ хүнд үгээр сүрдүүлэх, мохоон тулгаж хэлэлцэх,

БУРИМДУУЛАХ 1. буримдахын үйлдүүлэх хэв; 2. буримдагдах.

БУРНАГА зэгсний үндэс, бурнаа ч гэдэг.

БУРТАГ 1. бузар зүйл, бохир юм; **хир буртаг; хог буртаг; бузар буртаг** х о р ш . ; *буртаг болох;* 2. амьтны нярайлсны дараа умайгаас цувран гарах салиа; *буртаг шавхрах.*

БУРТАГЛАХ юмыг бузар муухай болгох.

БУРУУ зөв гэдэгтэй эсэргүүцэлдсэн утгатай үг; 1. зөв биш; *чи буруу ярьж байна; гажуу буруу; буруу зам; буруу үзэл;* **буруу харах** (эндүү ташаа харах); **буруу хэлэх** (ташаа хэлэх); **буруу санах** (муу санах *хар буруу санах);* 2. алдаатай хэрэг, гэм; *буруугаа хүлээ!; миний буруу;* 3. ар талаараа, гэдрэг; *буруу харах;* 4. солгой, зүүн; *буруу гар; буруу энгэр; морины буруу тал;* 5. цагийн зүүгийн эсрэг; *нар буруу эргэх;* ☆ **буруу номтон** (а. өөр шажинтан; б. шажны номоос гажуу үзэлтэн); **буруу хоолой** (амьсгал авах хоолой).

БУРУУДАХ хэтэрхий буруу болох.

БУРУУДУУЛАХ буруудахын үйлдүүлэх хэв; буруу болгох.

БУРУУЛАХ 1. зайлах, зугтах; **нүүрээ буруулах** (хүний өөдөөс харж чадахгүй); 2. зугтаах, оргон зайлах; *би буруулах хэрэг хийгээгүй, хэрэв буруулбал буруудна.*

БУРУУЛУУЛАХ буруулахын үйлдүүлэх хэв; буруулахад хүргүүлэх.

БУРУУТ буруу буй, буруу хэрэг таригч; *чи буруут болж байна.*

БУРУУТАЙ буруу бүхий этгээд, солгой ёс, зүйгээс гажуу.

БУРУУТАХ улам буруу болох, буруу хэрэг гаргах; *урууддахад буруутах* з ү й р.

БУРУУТГАХ буруутахын үйлдүүлэх хэв, зэмлэх, бурууг хүлээлгэх; *шууд чамайг буруутгах ёстой.*

БУРУУШААГДАХ буруушаахын үйлдэгдэх хэв.

БУРУУШААЛ буруушаах, зэмлэл, муушаал; *буруушаал хүлээлгэх.*

БУРУУШААЛГАХ 1. буруушаахын үйлдүүлэх хэв; 2. буруушаагдах.

БУРУУШААХ буруутган зэмлэх, муушаах; *битгий буруушаагаарай; төлөвлөгөөт ажлыг эс биелүүлбэл буруушаах болно.*

БУРХАН 1. буддын шашны ёсонд гэм бүхнийг тэвчиж, эрдэм бүхнийг гуглуулж, хамгийг эрхшээсэн хүн буюу бүрний (бүгдийн) хаан; *бурхан багш;* **бурхант газар, буг чөтгөр** (сайны хажууд муу); 2. шашны ёсны итгэл болсон элдэв дүрс хөргийн зүйл; *бурханд мөргөх; шавар бурхан; зурмал бурхан;* 3. бунхан; *бурхан суврага;* ☆ **цагаан бурхан** (цэцэг өвчин); **улаан бурхан** (улаан нут); **долоон бурхан** зурхай (долоон өвгөн).

БУРХАНГҮЙ: бурхангүйн үзэл шажингүйн үзэл; *бурхангүй газар бумба гэгчээр ....*

БУРХАНГҮЙЧҮҮД шажингүйн үзлийг баримтлагчид.

БУРХАНТАХ цэцэг өвчнөөр өвдөх.

БУРХИ гурван наснаас дээших эр тарвага; бозлог.

БУРХИРАХ утаа уур зэрэг юмны багсран оргилох; *утаа бурхирах.*

БУС 1. биш, үгүй; *тийм бус; хол бус газар; тогтмол бус; гишүүн бус; хууль бус хэрэг; түүгээр зогсох бус...; түүгээр зогсох төдий бус ...;* 2. өөр; *бус хүн байвал яахыг өөрөө мэд!; өгөхөөс бус аргагүй; бас бус хүн бий;* ☆ **цаг бусын аюул** (гэнэт тохиолдох аюул).

БУСАД өөр, үлдсэн; *бусад хүмүүс; бусад хэрэг; бусдын хамт явжээ; бусдын хүчинд автагдах; үүнээс бусад нь явсан.*

БУСАРМАГ бусрах зан байдалтай.

БУСАРМАГЛАХ бусрах муу ааш зан гаргах.

БУСАХГАРАХ гутам жигшим зүйлээс зэвүүрхэн зайлах.

БУСГАДАГ морь малын бусгамхай зантай; *бусгадаг мориноос ойчоод, булчдаг мориноос ойчлоо гэв.*

БУСГАМТГАЙ бустах зан дадалтай.

БУСГАМХАЙ бусгамтгай.

БУСГАХ 1. давхийн хажуу тийш **бултах;** *морь бусгав;* 2. шилжсэн бие зайлсхийхийг хичээх; *гэм зэмээс бусгах.*

БУСГУУЛАХ 1. бусгахын үйлдүүлэх хэв; 2. бусгагдах.

БУСЛАГ амьтан харцгайтай адил, цагаан өнгөтэй нэг зүйл шувуу, явлаг ч гэнэ.

БУСНИУЛАГЧ сүйтгэгч, үймүүлэгч, сарниулагч, бүрэлгэгч.

БУСНИУЛАХ буснихын үйлдүүлэх хэв, сарниулах, сүйтгэх, бүрэлгэх; *эд хөрөнгийг сарниулан бусниулах; амийг бусниулах* (хорлох); *гэрт байсан номыг бусниулсан байна; хов хэлж бусниулахыг завдав.*

БУСНИХ устах, мөхөх, сарних; *айл өрх эвдэрч бусних; эд хөрөнгө үрэгдэж бусних; адуу мал сарнин буснисан байна.*

БУСРААЧ урваач, үрээч, гөрлөөч.

БУСРАХ 1. амалсан зүйлээ буцаж няцах; *үгээ буцаж бусрах;* 2. хөрөнгө хогшлоо дэмий үрэгдүүлэх; *хөрөнгөө бусран хоосорчээ.*

БУСХИ үг явдал золигүй, этгээд муухай зантай хүн; *бусхи хүн, бусгадаг морь тун халгаатай.*

БУСХИЛАХ золигүй муухай гутам явах, жигшмээр ааш гаргах.

БУСЦАР 1. бус, өөр: **бусцар хэлбэл** (өөрөөр хэлбэл); 2. бусардаг зантай хүн.

БУТ I 1. уг орчимд салаалах модорхог ба өвсөрхөг ургамал; *харганын бут; бут ихтэй газар;* 2. туг, бөөн хэсэг; *бут үс;* ☆ **шоргоолжны бут** (шоргоолжны үүрэн дээр байгаа өвс зэргийн юм).

БУТ II хүч нэмэгдүүлэх үг; *бут киргэх; бут цохих.*

БУТАН бут; 1. **бутан хамхаг** ургамал (ихэнхдээ говь газар ургана; өргөст ба хар хамхгийн адил, навч бөөрөнхий уртлаг бөгөөд усархаг, таван хушуу хэлбэртэй үртэй байдаг).

БУТАРГАХ бутрахын үйлдүүлэх хэв; 1. хагалан тал тал тийш нь унагаах, хаялах, цацлах; 2. олон хэсэг болгон салгах; *мөнгө бутаргах;* 3. шилжсэн сарниулан тараах.

БУТАРХАЙ тархай, задгай; **тархай бутархай** хорш.; **бутархай тоо** (ямар нэгэн нэгж тооны хэсэг); **бутархай мөнгө** (задгай мөнгө);

БУТАРХАЙЛАХ бутархай болгох.

БУТАЧ хууль ёсны эцэггүй хүн.

БУТЛАХ I 1. бутрахын үйлдүүлэх хэв; *мөнгө бутлах;* 2. бутраах, бутруулах.

БУТЛАХ II бут бутаар багцлан ургах; *бутлаж ургадаг ургамлууд.*

БУТЛУУЛАХ бутлахын үйлдүүлэх хэв; бутлагдах.

БУТРААХ бутрахын үйлдүүлэх хэв; бутаргах.

БУТРАХ 1. хагаран хэсэг хэсэг болон салах задрах; *шилийг цохитол бутрав;* 2. шилж-

с э н сарнин тарах; *дайсны цэрэг бутраа зугтаав.*

БУТУУЛ ботиул.

БУТЧИХ байн байн буюу дахин дахин бутрах, бутлах.

БУТЧУУЛАХ бутчихын үйлдүүлэх хэв, бутчигдах.

БУУ I гол төмөртэй галт зэвсэг; *англйн буу; танк эсэргүүцэх буу; хоосон буунаас хорин хүн айх х у у ч. буу буудах;* **буу зэвсэг; буу шуу; буу цоор** х о р ш . ; *бууны гол төмөр; бууны гэр; бууны сум;* **бууны ам** (гол төмрийн ам); **бууны бөгс** (замгийн хойд тал); **бууны замаг** (гал авалцуулах хэсэг); **бууны овоо** (харааг тохируулах овгор); **бууны хараа** (сумны тусгал тохируулагч); **бууны хүхээ** (сум хийх хэсэг); **бууны сүмбэ** (гол төмөр цэвэрлэх хэрэгсэл); **бууны бянт** (гол төмрийн доторхи зураас); **буу тавих** (хий буудах); **их буу, үхэр буу** (урт гол төмөртэй, том сумтай, алст тусч чадах галт зэвсэг); **цахиур буу** (цахиураар гал авалцах буу); **гар буу** (авсаар жижиг буу, ойрхон буудахад хэрэглэнэ); **хоёр амтай буу** (хоёр гол төмөртэй буу); ☆ **буу загас** (халим)

БУУ II шооны нүхийг таалцан мөрийтэй наадах тоглоом.

БУУДАГЧ буудахдаа чадамгай, бууч; **мэргэн буудагч** (онц мэргэн бууддаг хүн).

БУУДАЙ I 1. цагаан гурил хийдэг тариа; *буудайн гурил; улаан буудай; тал дүүрэн арвай буудайн тариалан халиуран ганхаж байна;* 2. цагаан бор зүстэй малын үсэн дэх бяцхан бараан толбо; *буудайтай борогч гүү.*

БУУДАЙ II: **ээдий буудай элий балай.**

БУУДАЛ явуулын хүний зогсч амарсан хоноглосон буюу хоноглох, байрлах, буух газар; *буудлын газар; аянчны буудал; зочид буудал; нисэх онгоцны буудал; галт тэрэгний буудал.*

БУУДАЛДАХ харилцан буюу бусдын хамт буудах.

БУУДАЛЛАХ үдлэх, хоноглох; *жуулчид тосгоны ойролцоо буудаллав.*

БУУДАЛЛУУЛАХ буудаллахын үйлдүүлэх хэв.

БУУДАЛЦАХ буудахын үйлдэлцэх хэв.

БУУДАЛЦУУЛАХ буудалцахын үйлдүүлэх хэв.

БУУДАХ буугийн гох дарж, дарийг тэслэн сумыг явуулах; *винтовоор буудах; их буугаар буудсан ажээ; бай буудах; буудан алах.*

БУУДЛАГА буудах, дадлага хийх; *буудлагын газар; буудлагын талбай; их бууны буудлага хийх газар.*

БУУДУУЛАХ 1. буудахын үйлдүүлэх хэв; 2. буудагдах.

БУУДЧИХ буудаж орхих.

БУУДЧИХАХ буудчих.

БУУЗ татсан махыг элдсэн гурилд боон чимхэж, жигнүүрт жигнэн болгох хоол.

БУУЛГА тэргэнд хөллөх, малын хүзүүн дээгүүр тавьж уях бөгтөр мод; *буулганы оосор; тэрэгний буулга.*

БУУЛГАХ буухын үйлдүүлэх хэв, буухад хүрүүлэх; *шатаар буулгах; зураг буулгах; жин буулгах; ачаа буулгах; гэрээ буулгаж ачаалав; цалин буулгах; жуулчинг гэрээ буулгав; үнэ буулгах; тушаалаас буулгах; өртөөнөөс буулгах; бэрээмэг тосонд буулгах;* ☆ **бэр буулгах** (хүүдээ эхнэр авч өгөх);

БУУЛИУЛАХ буулихын үйлдүүлэх хэв; бүргэд харцага, нохой мэтийг ан амьтныг агнан барихад сургах.

БУУЛИХ бүргэд, харцага зэрэг амьтны, ан амьтныг агнан барьж сурч амтших; *бүргэд буулих.*

БУУЛТ I 1. бууж өгөх үзэгдэл; **буулт хийх** (өөрийн талаас зарим зүйлийг зөвшөөрөх); 2. цохилт; *далайц нь их ч буулт нь хөнгөн.*

БУУЛТ II шүү.

БУУР агтлаагүй эр тэмээ; *үхсэн буурын толгойноос амьд ат айна з ү й р;* **орсон буур** (ороо нь орсон буур).

БУУРАГЧ I буурсан юм; *бууравч этгээд; зориг нь бууравч.*

БУУРАГЧ II эм адууны зүс; *бууравч гүү.*

БУУРАЙ I дорой, ядуу; **дорой буурай** х о р ш . ; *хоцрогдсон буурай үндэстэн.*

БУУРАЙ II буурал; *буурай эмгэн.*

БУУРАЙХ 1. бууралтах; *буурайсан сайхан өвгөн;* 2. уул модонд цас, цан тогтож бууралтах.

БУУРАЛ I доройтол; *буурал суйрэл.*

БУУРАЛ II гол зүс буюу өнгөнд цайвар оролцсон; *буурал морь; буурал үнэг; улаан*

буурал морь; буурал морийг уная гэвэл будруулаад гарна а р д ы н д у у; **цал буурал** (маш буурал).

БУУРАЛТАХ буурал болох; *уулын орой буураллаж ирлээ; үс буураллах.*

БУУРАЛТУУЛАХ буураллахын үйлдүүлэх хэв; *хавар цас хайлж газрын хөрс буураллуулав.*

БУУРАХ 1. доошлох, нам болох; *халууны илч буурав;* 2. хямд болох; *барааны үнэ буурчээ;* 3. доройтох, муудах, буурай болж ягуурын байдалд хүрэхгүй болох; *капиталист аж үйлдвэрийн хөгжилт үргэлжлэн буурсаар байна.*

БУУРЖ х у у ч и р с а н хоёр үе болсон боол.

БУУРИЛАХ 1. буудаллан суух; 2. суурилах, уллах; буурьтайгаараа түрээ барих.

БУУРУУЛАХ буурахын үйлдүүлэх хэв; *чадлыг буруулах; тушаалы нь буруулах.*

БУУРЦАГ хуй (хүүдий) доторт үрэлдэг ургамлын мөхлөг.

БУУРЬ 1. юмыг гавих цогцлох суурь ором; *Гэрийн буурь;* 2. эзэлж байвал зохих суурь; *буурь суурь; бөхийн буурь.*

БУУХ 1. дээрээс доош болох; *шатаар буух; уулнаас буух; сүүдэр буух; үер буув; солир бууж гэнэ; манан буух; тоос буух;* 2. унаа хөсөг дээрээс доошлон газарт гишгэх; *мориноос буух; галт тэрэгнээс буух; буун харайх;* 3. цогцлон байгуулсан зүйл цуцрах, байхгүй болох; *бууж байгаа байшин; гэр буух;* 4. цалин хэрэглэл мэтийн албан газраас олгох зүйлийг авах; *цалин буух үе;* 5. түр буюу удаан хугацаагаар орших нутаглах; *манайх дабааны ард буув; аянчин үдлэхээр буужээ; хотод ирээд ахындаа буув;* 6. унаатай яваад айлд орох; *амраг жаахан түүнийхээ аашинд нь буугаад мордоно* а р д ы н д у у; 7. юмны үнийн хямдрах; *Зөвлөлт Улсад сүүлийн таван жилд бараа товарын үнэ хэд дахин буужээ;* 8. албан тушаалаас буурах; ☆ **татан буух** (албан газар огцрон ажиллахыг болих); **бууж өгөх** (хүч ялагдан дагаар орох); 9. албаны хугацааг дуусган ажиллахыг болих; *манаанаас буух; жижүүрээс буух; цэргээс буух;* 10. юмны шим шингэн зүйлд шингэх; *цайны идээ буув;* 11. ш и л ж с э н ухагдах ойлгогдох; *ухаанд буух.*

БУУХИА 1. х у у ч и р с а н зарлиг мэдээг бичлэн хүргэх элч; 2. чухал яаралтай бичиг; *буухиа бичиг; буухиа дамжуулах;* **буухиа өөртөө** (зарлигаар байгуулсан өртөө); *борооны түрүүнд шороо, богдын түрүүнд буухиа* з үй р; 3. ш и н э ямар нэг тодорхой хэмжээний газар хурдлан гүйж, халаа авах хүмүүст юмыг дамжуулан өгөх зэргээр өртөөлөн уралдах уралдаан.

БУУХИАЛАХ өртөөлөх, буухиалж зөөх.

БУУЦ 1. нутаглаж буудаллаж байсан газар; *айлын бууц; аянчны бууц;* 2. нутаглаж байсан газрын малын өтөг баас; *бууцны хөрзөн; хотны бууц; бууц арилжих; өвөлжөө бууц; өтөг бууц;* 3. эрт дээр цагийн хүний оршин сууж байсан газрын ором; *хуучин чулуун зэвсгийн үеийн бууц; шинэ чулуун зэвсгийн үеийн бууц.*

БУУЧ 1. буудахдаа чадамгай хүн; *мэргэн бууч;* 2. буудах ангийн цэрэг.

БУФЕТ хөнгөн зуушны газар.

БУФЕТЧ хөнгөн зуушны газар үйлчлэгч хүн.

БУХ (Н) агтлаагүй эр үхэр; *бух тавих; сайн үүлдрийн бух;* **бухан бяруу** (хоёр настай агтлаагүй эр үхэр); **бух гөрөөс** а м ь т а н (зэрлэг үхэр бухтай төстэй, цээж өндөр, бөгс шувтан өнгө хөх); **бух шувуу** а м ь т а н (хулс зэгстэй усанд оршино; усанд хүшуугаа дүрж дугарах нь маш хол сонсогдоно, их дэглийгээс багахан, бага дэглийгээс иххэн, үхрийн урамдах адил дугарна): **бухын сүүл** у р г а м а л (хяруу унасан хойно гарах хөх цэцэг); **хөх бух** а м ь т а н (бор шувууны баг, бидэртэй жижиг шувуу); **бух нохой** а м ь т а н (цээж өргөн, хөл намхан, хоншоор том болоод богино нэг зүйл нохой); **бух тэрэг** (галт тэрэгний толгой).

БУХААР адууны элдэж боловсруулсан шир; *бухаар гутал.*

БУХАЛ хэсэг хэсэг шовойлгон овоолсон өвс, тариа; *олон бухал холоос харагдав.*

БУХАЛДАХ бухал болгох; *манайхан өвсөө бухалдаж байна.*

БУХАЛЛАХ бухалдах, бухал болгох.

БУХАЛШИХ ваалан гутах, үнэр амт хувилах; *тариа нь бухалшсан байв.*

БУХАНДАЙ: бухандай дэл морины хөхөл үлдээлгүй зассан дэл; **бухандай бяруу** (агтлаагүй бяруу). •

БУХАНДАЙЛАХ бухандай дэл болгон хяргах.

БУХАР: бухар тариалан тариалан тариагүй удсан тариалангийн газар.

БУХАХ 1. тонгорон булгих; *эмнэг морь эмээлээ бухав;* 2 .бөхийн мэх, ташаалдан тонгорох; 3. ш и л ж с э н өөрийн хийвэл зохих зүйл буюу гэм зэмлэлийг бусад руу түлхэж орхих; *буруугаа бусдад бухах; алдаагаа над руу бухах санаатай байв.*

БУХДАХ бухны үнээнд нийлэх.

БУХИМДАЛ бухимдах үйлийн нэр; *над бухимдалтай хэрэг болсон.*

БУХИМДАЛТАЙ бухимдал бүхий, бухимдвал зохиолтой.

БУХИМДАМ бухимдалтай, бухимдмаар.

БУХИМДАХ бухимдуу байдал гаргах, уйдаж тэсэхгүй болох, бачуурах, уур хүрч бачимдах, тачаадах; *дотор бухимдах.*

БУХИМДУУ бачим, тэвдүү, сандруу; *бухимдуу хүн өөртөө зовлонтой.*

БУХИМДУУЛАХ бухимдахын үйлдүүлэх хэв, бухимдахад хүрүүлэх.

БУХЛИГ: бухлиг хулгана а м ь т а н хулганатай адил, бие том, сүүлгүй.

БУХСАХ үнээний бух хүсэх.

БУХТАХ эр үхрийн бух байдал гаргах.

БУХУУЛАХ 1. бухахын үйлдүүлэх хэв; 2. бухагдах.

БУЦААЛГАХ 1. буцаахын үйлдүүлэх хэв; 2. буцаагдах.

БУЦААЛТ буцаасан юм; **мөнгөний буцаалт** (мөнгөний хариулт).

БУЦААХ буцахын үйлдүүлэх хэв; **буцааж авах** (эргүүлэн авах).

БУЦАЛГАХ буцлахын үйлдүүлэх хэв; буцлахад хүрүүлэх.

БУЦАЛГУУР I ус буцалгах сав, багаж.

БУЦАЛГУУР II ингэний сүүнд айраг буюу хоормог самарч хийдэг нэгэн зүйл цагаан идээ.

БУЦАЛТ буцах үйлийн нэр.

БУЦАЛТГҮЙ эргэлтгүй; *буцалтгүй тусламж; буцалтгүй үг.*

БУЦАХ 1. гэдрэг эргэх; *нутагтаа буцах; гэртээ ирээд буцаж явав;* 2. ш и л ж с э н няцах, ухрах; *хэлсэн амаа буцав; хийхээс буцахгүй.*

БУЦАШ: буцаш хорхой а м ь т а н хүн амьтны гэдэс доторт оршиж шимийг сорогч хорхой, унь хорхойн адил бөгөөд урт.

БУЦАШГҮЙ буцахын аргагүй, буцалтгүй.

БУЦЛАМ буцламгай; *буцлам халуун цай.*

БУЦЛАМГАЙ буцалж байгаа; *буцламгай халуун ус.*

БУЦЛАХ 1. шингэн юм маш халж оргилох; *цай буцалж байна; буцалсан ус;* 2. шингэн юманд юм чанах, болгох; *тогоотой хоол буцлах;* 3. ш и л ж с э н ихэд уурлах, хор хөдлөх; *уур буцлах; хор шар буцлах.*

БУЦУУЛАХ 1. буцахын үйлдүүлэх хэв; 2. буцаах, буцаагдах.

БУЧИГНАХ бужигнах, үймэх, үймцэх; *олон амьтан бучигналдаж хөл хөдөлгөөн ихтэй байгаа бололтой; шороо бучигнах.*

БУШУУ 1. түргэн; *энэ ажлыг бушуу дуусгах хэрэгтэй!;* 2. хурдан; *бушуу туулай борвиндоо баастай* з ү й р.

БУШУУЛАХ түргэлэх, хурдлах; *бушуулаарай! бушуулаарай, би яарч явна.*

БУШУУХАН 1. баахан бушуу; 2. бүр бушуу.

БУЮУ 1. эсвэл, юм уу, юм үү; *мод буюу төмөр;* 2. аюу; *сайтар үзнэм буюу; энэ хоолыг иднэм буюу;* ☆ **арга буюу** (аргагүй, аргагүй болоод; *арга буюу нуулгүй хэлчихсэн билээ).*

БУЯН ш а ш и н сайн үйл хийхийн нэр; *арван цагаан буян; буян хийх; буян хишиг;* **заяа буян** х о р ш..

БУЯНТ буян бүхий; *буянт хүний буянаар.*

БУЯНТАЙ буянт; *буянтай сэтгэл; буянтай айл; буянтай үйл.*

БУЯНТАН х у у ч и р с а н дээдэс, сайн сэтгэлтэн, энэрэнгүй, өглөгч хүн.

БУЯНЧ буянт үйл хийхдээ дуртай.

БҮВНЭХ үгийг тодорхойгүй дутуу хэлэх; *бүвэн бавнан хэлэх.*

БҮВЭГНЭХ 1. тодорхой бус ярих; 2. үйл ажилд дорой яданги байдалтай хөдлөх; *бүвэгнэн хөдөлж ядаж явна.*

БҮВЭР: бүвэр бялзуухай а м ь т а н бүвээлжин шувуу; **бүвэр загас** а м ь т а н (нэг зүйл загас).

a religious ceremony performed for a deceased person

БҮВЭЭЛЖИН бөвөөлжин.

БҮГ бөг.

БҮГД 1. булт, цөм, бүхэн; *бүгд улс; бүгд хууль; бүгд хурал; бүгд найрамдах улс; бүгдийн хөрөнгө; бүгд нийлж нэг мянга болов; бүгд дүн; бүгдийн хүчээр; бүгдийн төлөө;* 2. бүр, тутам; *айл бүгд; хүн бүгд.*

БҮГДЭЭР булталр, цөмөөр, цугаар; *бүгдээрээ сууж байв; та нар бүгдээр насанд хүрэгсэд, бүгдээр сонгуульд оролцогтун!*

БҮГНЭГДЭХ бүгнэхийн үйлдэгдэх хэв.

БҮГНЭМ: бүгнэм халуун салхигүй бүгчим халуун; *бүгнэм халуун өдөр.*

БҮГНЭХ 1. битүү дарж, халуун дулаан байлгах; 2. жигнэх, халаах; **бүгнэх жигнэх, дарах бүгнэх** х о р ш..

БҮГТ илэрхийгүй, бүрхэг; *бүгт өнгө; бүгт хэрэг.*

БҮГТДЭХ хэтэрхий бүгт болох.

БҮГТРҮҮЛЭХ бүгтрэхийн үйлдүүлэх хэв.

БҮГТРЭХ 1. бүгт болох, тодорхой биш болох; 2. үгдрэх; *ханиад бүгтрэх.*

БҮГТХЭН баахан бүгт.

БҮГҮҮЛЭХ бүгэхийн үйлдүүлэх хэв.

БҮГЧИМ бүгнэм, бачим; *бүгчим халуун; бүгчим амьсгах.*

БҮГЧИМДҮҮЛЭХ бүгчимдэхийн үйлдүүлэх хэв.

БҮГЧИМДЭХ бүгчимд тэсч ядах; *дотор бүгчимдээд байна.*

БҮГЧИМХЭН баахан бүгчим.

БҮГШИХ 1. бүгчимдэх; *бүгшин инээх; бүгшин ханиах;* 2. нуугдах, сэм хуйвалдах, бүүрлэх; *бүгшсэн хулгай; цэрэг бүгших.*

БҮГШҮҮЛЭХ бүгшихийн үйлдүүлэх хэв, бүгшихэд хүргүүлэх.

БҮГЭХ 1. нуугдах, далдлан хоргодох; *ууланд бүгэх; айлд бүгэх;* 2. чичрэх, дагжих; **чичирч бүгэх; дагжиж бүгэх** х о р ш.

БҮГЭЭВТЭР бүгээн зүс дийлэнх; *бүгээвтэр адуу харагдана.*

БҮГЭЭДЭХ хэтэрхий бүгээн болох.

БҮГЭЭН цайруу, бараан биш; *бүгээн өнгөтэй морь; бүгээн зүсмийн адуу.*

БҮГЭЭРЭХ бүгээн болох.

БҮДГЭВТЭР баахан бүдэг; *бүдгэвтэр өнгө.*

БҮДНҮҮР у р г а м а л говь хонхор хоолой төхөм хөндий газар ургана; өндөр нь 20 см. орчим, цагааалжийн байдалтай бөгөөд бяцхан навчтай, иш үзүүртээ дэрсний толгойн хэлбэртэй, түрүүд нь хуурсны адил шаравтар цагаан үр гарна, чанар тослог, үнэр баахан заартай мэт.

БҮДНЭ бөднэ; **бүднийн сүүл** у р г а м а л (бөднийн сүүл).

БҮДРҮҮЛЭХ бүдрэхийн үйлдүүлэх хэв.

БҮДРЭХ 1. хөл юманд торж бие тэнцүүр алдан унах шахах; *будэрч ойчих; морь будрэв;* 2. ш и л ж с э н осолдон буруудах; *алдаж будэрч л явна.*

БҮДҮҮВЧ тоймлон төлөвлөж гаргасан зураг ,бичиг; *бүдүүвч зохиох; бүдүүвч гаргах.*

БҮДҮҮВЧЛЭХ нарийвчлахгүйгээр барагцан үйлдэх ажил; *бүдүүвчилсэн төлөвлөгөө; бүдүүвчлэн хийхээс биш барагдахгүй нь.*

БҮДҮҮДҮҮЛЭХ бүдүүдэхийн үйлдүүлэх хэв.

БҮДҮҮДЭХ хэтэрхий бүдүүн болох.

БҮДҮҮЛЭГ 1. уран биш, болхи; *бүдүүлэг хийцтэй эдлэл;* 2. ш и л ж с э н эрдэм соёлгүй, боловсон биш, харанхуй хоцрогдсон; *бүдүүлэг хүн.*

БҮДҮҮЛЭГДЭХ болхидох, хэтэрхий бүдүүлэг болох.

БҮДҮҮЛЭГЛЭХ 1. бүдүүлэг байдал гаргах; 2. үйл ажлыг хуумгай хийх.

БҮДҮҮЛЭХ нарийлахгүй, бүдүүн тоймоор үзэх.

БҮДҮҮН нарийнтай өсэргүүцэлдсэн үг; 1. нарийн биш; *бөх хүн бүдүүн өвсөнд з ү й р; бүдүүн ширхэгтэй;* 2. нас гүйцсэн том; *бүдүүн шар; бүдүүн үхэр;* 3. дуу хоолойны өтгөн; *бүдүүн хоолой; бүдүүн дуугаар дугарах;* 4. нарийн, сайн, сайхан биш; *бүдүүн бараа; бүдүүн гурил;* 5. бүдүүлэг болхи; нарийн журмыг үл мэдэх; **бүдүүн хадуун** х о р ш.; *бүдүүн айл;* 6. ур муутай; *бүдүүн зурсан зураг; бүдүүн хийцтэй эд;* **бүдүүн гэдэс** (гэдэсний хошноготой залгаж байгаа хэсэг).

БҮДҮҮРҮҮЛЭХ бүдүүрэхийн үйлдүүлэх хэв.

БҮДҮҮРЭХ 1. бүдүүн болох, томрох; 2. таргалах; *чи улам бүдүүрч байна;* 3. нарийн уран биш болох.

БҮДҮҮСГЭХ бүдүүтгэх, бүдүүрүүлэх.

БҮДҮҮСЭХ улам бүдүүн болох.

БҮДҮҮТГҮҮЛЭХ бүдүүтгэхийн үйлдүүлэх хэв.

БҮДҮҮТГЭХ бүдүүн болгох, бүдүүсгэх.

БҮДҮҮТЭХ улмаар бүдүүн болох, бүдүүсэх.

БҮДЧИХ байн байн бүдрэх.

БҮДЭГ 1. тод биш; *бүдэг гэрэл; бүдэг харагдах;* 2. ш и л ж с э н мунхаг, хөтх, **бүдэг хөтх** х о р ш..

БҮДЭГДЭХ хэтэрхий бүдэг болох.

БҮДЭГРҮҮЛЭХ бүдэгрэхийн үйлдүүлэх хэв; *тод бүгдийг бүдгэрүүлэх.*

БҮДЭГРЭХ бүдэг болох.

БҮДЭГТЭХ бүдэгрэх, бүдэг болох.

БҮДЭГХЭН баахан бүдэг.

БҮДЭНГЭ нүдний аньсга буунги; *бүдэнгэ аньсгатай; бүдэнгэ зовхитой.*

БҮДЭНГЭРЭХ бүдэг болох, улам бүдгэрэх.

БҮДЭРХИЙ амьтны өвчүүний дээд шомбогор хэсэг; *өвчүүний бүдэрхий.*

БҮДЭРХЛЭХ хүн малын явахад хөл нь байн байн торох.

БҮДЭХ бүдэг, бүрэг.

БҮДЭХРЭХ бүдэгрэх, бүдэх болох.

БҮЖИГ 1. уран хөдөлгөөнт урлаг; *бүжгийн онол; бүжгийн төгс чадвар;* 2. хөгжмийн аялга, айзмаар гүйцэтгэх хөдөлгөөн; *классик бүжиг; бүжгийн сургууль; дуу бүжгийн чуулга.*

БҮЖИГЛҮҮЛЭХ бүжиглэхийн үйлдүүлэх хэв.

БҮЖИГЛЭХ бүжиг хийх; *би та нарт нэг бүжиг хийж үзүүлье гэв.*

БҮЖИГЧ бүжиглэхэд чадамгай хүн.

БҮЖИХ бүжиглэх.

БҮЙЛ шүдний уурхайг халхлан ургасан мах; *бүйл хавдах.*

БҮЙЛС буйлс.

БҮЙЛЭЭС бүйлс.

БҮЛ I 1. эгч охин дүү **хоёроос** төрсөн хүүхэд хоорондоо бүл болно; 2. гэрийн доторхи туслах хүн; **ам бүл** х о р ш.; *манайх хүн бүл муутай;* **бүл зээ ураг** (нагац эгч нагац хүргэн ах, нагац авга эгчийн хүүхэд); **бүл ач** (бүл ах дүүгийн хүүхэд); **гэр бүл** (гэрийн доторхи хүн ам); **гэр бүл болох** (гэрлэх).

БҮЛ II хүч чадал; *бүлтэй эр; гарын бүлээр илүү.*

БҮЛБИЙЛГЭХ бүлбийхийн үйлдүүлэх хэв.

БҮЛБИЙХ бүлбэгэр болох.

БҮЛБЭГНЭХ 1. бүлбэгэр юмны үргэлжлэн хөдлөх; 2. ш и л ж с э н шийдэмгий биш байдал гаргах.

БҮЛБЭГЭР 1. үлбэгэр, сул, дорой, баргтай, муухан; *бүлбэгэр биетэй хүн; бүлбэгэр ястай эд;* 2. амт ааг муу; *бүлбэгэр хоол; бүлбэгэр айраг.*

БҮЛБЭЛЗЭХ бүлбэгэр юмны байн байн хөдлөх.

БҮЛБЭР бүлээхэн; *бүлбэр цай; бүлбэр усаар уу!*

БҮЛГЭМ ямар нэг үйл явдлыг хамтран хийхээр хэсэг бүлэг болсон нь; *утга зохиолын бүлгэм; намын нууц бүлгэм; бүлгэмийн удирдагч.*

БҮЛГЭМДЭХ бүлгэм болон нэгдэх.

БҮЛГЭМНҮҮЛЭХ бүлгэмнэхийн үйлдүүлэх хэв.

БҮЛГЭМНЭХ бүлгэмдэх.

БҮЛДЭХ 1. олноор хамжих; *бүлдэж хийвэл бүр ч хялбар гүйцнэ;* 2. хүчдэх, хүч гаргах; 3. морь малын хөгжиж тэмүүлэх; *морь бүлдэх.*

БҮЛТ хүч нэмэгдүүлэх үг; *бүлт цохих; бүлт татах; бүлт үсрэх.*

БҮЛТГЭР овгор товгор, овойж гарсан; *бүлтгэр нүдтэй; хоёр тал нь бүлтгэр шил.*

БҮЛТГЭРДЭХ бүлтгэрийн учир зохисгүйдэх.

БҮЛТГЭРХЭН баахан бүлтгэр.

БҮЛТИЙЛГЭХ бүлтийхийн үйлдүүлэх хэв; *нүдээ бүлтийлгэн харж байв.*

БҮЛТИЙХ бүлтгэр болох; *уурлан нүд нь бүлтийв.*

БҮЛТЛҮҮЛЭХ бүлтлэхийн үйлдүүлэх хэв.

БҮЛТЛЭХ бүлтгэрдүү юмыг мултрахад хүргүүлэх.

БҮЛТРҮҮЛЭХ бүлтрэхийн үйлдүүлэх хэв.

БҮЛТРЭХ юм сугарч мултрах; *нүд бүлтрэх; хувингийн ёроол бүлтэрч унажээ.*

БҮЛТЭГНҮҮЛЭХ бүлтэгнэхийн үйлдүүлэх хэв.

БҮЛТЭГНЭХ бүлтгэр юмны бүлтэг бүлтэг хийх; *нүд нь бүлтэгнэх.*

БҮЛТЭЛЗҮҮЛЭХ бүлтэлзэхийн үйлдүүлэх хэв.

БҮЛТЭЛЗЭХ бүлтгэр юмны бүлтэс бүлтэс хөдлөх; *хоёр нүд нь бүлтэлзэн нааш цааш харав.*

БҮЛТЭН нүд зэрэг юмны бүлтгэр; *нүд бүлтэн, хамар шулуун.*

БҮЛТЭХ морь малын хөөрөн тэмүүлэх; *морь бүлтэх.*

БҮЛҮҮЛЭХ 1. бүлэхийн үйлдүүлэх хэв; 2. бүлэгдэх.

БҮЛҮҮР 1. бүлэх зэвсэг, хавтгай буюу хөмөрсөн аяга мэт голдуу модон юмыг дунд нь нүх гарган ишлэн хийнэ; *айргийн бүлүүр; хөөрцөгний бүлүүр;* 2. машины поршень.

БҮЛХ булчингийн нягт, хатуувтар шөрвөс мэт юм; *бүлхтэй мах.*

БҮЛХГЭР бяцхан овгордуу бөгөөд нойтон нялцгай; *уйланхай шиг бүлхгэр; бүлхгэр олгой;* 2. эд юмны яс чанар муутай; *бүлхгэр цаас;* 3. амт муутай улбагар; *бүлхгэр цай.*

БҮЛХИЙЛГЭХ бүлхийхийн үйлдүүлэх хэв.

БҮЛХИЙХ 1. бүлхгэр болох, улцгар, улхгар юм багашиг овойх; цэр бүлхийж харагдав; 2. шилжсэн дотор аягүй болох, бүлбийх; *дотор бүлхийх.*

БҮЛХЭГНЭХ бүлхгэр юмны бүлхэг бүлхэг хөдлөх.

БҮЛХЭЛЗЭХ бүлхгэр юмны бүлхэс бүлхэс хөдлөх.

БҮЛЦГЭР овгор, цулцгэр, цэлцгэр; *бүлцгэр нүдтэй.*

БҮЛЦИЙЛГЭХ бүлцийхийн үйлдүүлэх хэв.

БҮЛЦИЙХ бүлцгэр болох; *бүлцийтэл уйлах.*

БҮЛЦЭГНЭХ бүлцгэр юмны бүлцэг бүлцэг хөдлөх.

БҮЛЦЭЛЗЭХ бүлцгэр юмны бүлцэс бүлцэс хөдлөх.

БҮЛЦЭН нүд зовхи бүлцгэр; *бүлцэн нүдтэй.*

БҮЛЭГ 1. хэсэг, анги; *бүлэг этгээд; бүлэг сурагчид;* 2. ном, хөгжим, кино, жүжиг зэрэг зохиолыг хуваасан анги хэсэг; *гуравдугаар бүлэг; хэдэн бүлэг кино вэ?*

БҮЛЭГЛҮҮЛЭХ бүлэглэхийн үйлдүүлэх хэв.

БҮЛЭГЛЭХ 1. хэсэг анги болгон хуваах; 2. ном зохиол зэргийг хэсэг ангид хуваах; 3. хэсэг анги болон нэгдэх; *бүлэглэн загнах; бүлэглэсэн хэрэг.*

БҮЛЭН I өтгөрсөн цус.

БҮЛЭН II харвалгын бай.

БҮЛЭНТЭХ шингэн цус өтгөн болох; *цус бүлэнтэх.*

БҮЛЭНЦЭР хоёр бүлээс төрсөн хүүхэд хоорондоо бүлэнцэр болно; *бүлэнцэр зээнцэр* (бүл зээ ургийн хүүхэд).

БҮЛЭРХҮҮ 1. хүн ам олонтой; *бүлэрхүү айл;* 2. хүч тэнхээтэй; *энэ хүн юм өргөхдөө бүлэрхүү байна шүү.*

БҮЛЭРХЭХ 1. хүн бүл олонтойдоо бардамнах; 2. чадал тэнхээ ихтэйдээ бардамнах.

БҮЛЭХ 1. бүлүүрээр дээш доош цохилон хутгах; *айраг бүлэх;* 2. чичих хатгах; *шөвгөөр бүлэх; хутгаар бүлэх.*

БҮЛЭЭВТЭР дөнгөж бүлээн; бүлээвтэр цай.

БҮЛЭЭДЭХ хэтэрхий бүлээн болох, бүлээсэх.

БҮЛЭЭН зөөг, халуун биш, хүйтэн биш; *бүлээн цай; халуун бүлээн; сэрүүн бүлээн; эх орныхоо төлөө халуун амь, бүлээн цусаа хайрлахгүй тэмцэх.*

БҮЛЭЭНТЭЙ өвчний халуун; *хүүхэд бүлээнтэй байна.*

БҮЛЭЭРҮҮЛЭХ бүлээрхийн үйлдүүлэх хэв.

БҮЛЭЭРЭХ 1. дулаарах, дулаан, бүлээн болох; *цаг бүлээрэх;* дулаарах бүлээрэх хорш.; 2. өвчнөөр багашиг халуурах буюу хүүхдийн халуурах; *цэцгийн тарилга хийлгэсэн хүн бүлээрчээ.*

БҮЛЭЭСГЭХ бүлээсэхийн үйлдүүлэх хэв.

БҮЛЭЭСЭХ 1. бүлээн болох, багашиг халах; *цай бүлээсэв;* 2. нилээд дулаацах; *хөл бүлээсч байна.*

БҮЛЭЭТГЭХ бүлээсгэх.

БҮЛЭЭТЭХ бүлээсэх.

БҮЛЭЭХЭН баахан бүлээн.

БҮЛЭЭЦҮҮЛЭХ бүлээцэхийн үйлдүүлэх хэв.

БҮЛЭЭЦЭХ бага зэрэг дулаацах, бүлээн болох; *гар хөл бүлээцэх.*

БҮНХГЭР бүнхэр.

БҮНХИЙЛГЭХ бүнхийхийн үйлдүүлэх хэв.

БҮНХИЙХ бүнхэр болох, бүнхийн харагдах.

БҮНХЭР тал бөөрөнхийвтөр хэлбэртэй юм; *бүнхэр оройтой байшин.*

БҮНШИХ 1. тачаадан уйлах; *бүншин уйлах;* 2. гэншигнэн улих; *чоно бүншин ульж байв;* **гэншин бүншин; гэнших бүнших** х о р ш . .

БҮР 1. тутам; *жил бүр; гэр бүр; морь бүрийг эмээллэх; унших бүр ойлгогдож байв; явах бүр газар ойртож байв; угаах бүр цэвэр болсоор байв; хүн бүрд өг!;* 2. хамгийн, маш; *бүр хол; бүр чанга дуугарга!; бүр сайхан; бүр хатуу; бүр чухал зүйл;* ☆ **бүр түр** (энд тэнд, алаг цоог, бүдэг бадаг; *бүр түр санаанд орж байв; бүр түр мэдкэ);* 3. бүрмөсөн; *манайх бүр хотын айл болсон.*

БҮРВАБАДИРАБАД з у р х а й сарны зурхайн ёсны хорин найман одны нэг.

БҮРВАБАЛГҮНЬ з у р х а й сарны зурхайн ёсны хорин найман одны нэг.

БҮРВАСЭД з у р х а й сарны зурхайн хорин найман одны нэг.

БҮРГЭД а м ь т а н харцагын аймгийн махир хушуутай, маш их чадалтай, махчин том шувуу, уул талд оршино; *бүргэдийн дэвэлтээр дэвэн ...*

БҮРГЭЛЗҮҮЛЭХ бүргэлзэхийн үйлдүүлэх хэв.

БҮРГЭЛЗЭХ 1. юм бүрэлзэн бүрхэн муу харагдах; *нүд бүргэлзэх; бүргэлзэх бараа;* 2. бүрэг бараг санагдах; *сэтгэлд одооноос бүргэлзэх төдий болж байна.*

БҮРГЭХ I бургих; *шороо бүргэх.*

БҮРГЭХ II олны яаран сандрах, дайсны хэлмэн самуурах.

БҮРД газраас ундран гарч хол урсахгүй тогтсон бааxан ус; **шанд бүрд** х о р ш . .

БҮРДҮҮЛЭХ бүрдэхийн үйлдүүлэх хэв.

БҮРДЭЛ бүрэн төгс байдал; *бүрдэл болов; бүрдэл болсонгүй.*

БҮРДЭХ бүрэн болох; *ирвэл зохих төлөвлөгчид бүрдэж ирээгүй байна; мэдээ бүрдэжгүйцэв; хэргийн учир бүрдэх.*

БҮРЖИХ 1. бүрэлдэх; **цус бүржих** (нөжрөх); 2. бүрэх, хучих; **жимс бүржих** (жимсийг чихэр амтлаг зүйлээр бүрэх).

БҮРИЙ I нар шингэж арайхан харанхуй болоогүй үе; *үдшийн бүрий болов; харуй бүрийгээр;* **бүрий баруй** х о р ш . .

БҮРИЙ II бүр, эцэс; *хүн бүрийд хүргэ; энэ хэргийг бүрий дээр нь болъё.*

БҮРЛЭГЧ 1. талийгаач, гэнэтийн ослоор нас барагсдыг цээрлэн нэрлэх нэр; 2. сүйдэгч.

БҮРЛЭХ сүйдэх, үрэгдэх; *амь бүрлэх; хөрөнгө бүрлэх.*

БҮРЛЭЭЧ 1. бүрлэгч; 2. бүрэлгэгч, сүйтгэгч.

БҮРМӨСӨН бүр, бүрэн, нэгмөсөн; *бүрмөсөн өгөх; тамхийг бүрмөсөн хаяв; бүрмөсөн хотын хүн болжээ.*

БҮРНАВАС з у р х а й сарны зурхайн ёсны хорин найман одны нэг.

БҮРНЭЭ дуусган, цөм, цугаар, бүгд; *даалгасан ажлыг бүрнээ дуусган буцаж ирэв.*

БҮРС: бүрс барс бүрэг бараг; *айлын бараа холоос бүрс барс харагдав.*

БҮРТГЭГЧ бүртгэх ажлыг эрхэлсэн хүн: *тоо бүртгэгч.*

БҮРТГЭЛ байвал зохих юм бүхэн, уг тоондоо буй эсэхийг шалган бичих тэмдэглэгээ; **тоо бүртгэл** х о р ш . ; *бүртгэл гаргах;* **цэргийн бүртгэл** (цэргийн насны ардад хадгалуулах дэвтэр); *хүн амын бүртгэл; малын тоо бүртгэл; тоо бүртгэлийн газар; төлөвлөгөө тоо бүртгэл.*

БҮРТГЭХ 1. байвал зохих юм бүхэн уг тоондоо буй эсэхийг шалгах тэмдэглэх; *жагсаалд ирэгчдийг бүртгэх; иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх товчоо;* 2. бүрэн болгох, бүрдүүлэх; *бүртгэн авах; бүртгэж гүйцээх.*

БҮРҮҮЛЭХ бүрэхийн үйлдүүлэх хэв; *гэрээ бүрүүлэх; тараг бүрүүлэх.*

БҮРХ I 1. аяны буюу отрын хүмүүсийн хэрэглэх оромж; 2. монгол гэрийн хэлбэртэйгээр хийж шавардсан гэр.

БҮРХ II: **бүрх малгай** тэнзэн малгай; дэрсэн малгай.

БҮРХИЙ 1. холын юмны үзэгдэх бараа; 2. бүдэг хараатай болсон нүд.

БҮРХҮҮЛ бүтээж халхлах зүйл; *моторын бүрхүүл; дэнгийн бүрхүүл; бүрхүүлтэй тэрэг.*

БҮРХЭВЧ бүрхэн бүтээсэн юм; **агаар бүрхэвч** (дэлхийг бүрхсэн хийн мандал); **усан бүрхэвч** (дэлхийн хатуу гадрага, хийн мандал хоёрын завсар байдаг усан бүрхүүл, үүнд далай, тэнгэс, гол нуурууд орно; усан бүрхэвч нь дэлхийн гадрагын 70,8 хувийг эзэлнэ); **салст бүрхэвч** (хоол боловсруулах, амьсгалах зэрэг эрхтний дотор талын бүрхүүл);

БҮРХЭГ үүл бүрхсэн; бүрхэг өдөр.

БҮРХЭГДЭХ 1. бүрхэхийн үйлдэгдэх хэв; 2. ухаан муудах.

БҮРХЭГЛЭХ бүрхэг болох.

БҮРХЭХ юмаар битүүлэн нөмөргөн хучих; *хөшөөг нээхийн өмнө цагаан даавуугаар бүрхэж байв; тэнгэр бүрхэв; нүд бүрхэх.*

БҮРХЭЭР тогоо нэрэхэд тогоон дээр тавих мод, бургасаар хийсэн ёроол хавхаггүй, торх суулга мэт хэрэглэл, дээрээс нь жалавч тавина.

БҮРХЭЭС бүрхүүл, бүрхсэн юм.

БҮРЧИГ юмыг бүрхүүлэх хуниастай уут мэт сав; *малгайн бүрчиг.*

БҮРЧИГЛЭХ юмыг бүрчигт хийх; *нарны халхаа бүрчиглэв.*

БҮРЭГ 1. тод биш, бүдэг бадаг, цагаан биш, хар биш; **бүрэг цай** (бага сүүтэй цай); 2. шилжсэн ичимтгий, дорой, даруу; *бүрэг хүүхэд;* **бүрэг бараг** хорш.. *бүрэг бараг бараа харагдана; ухаан бүрэг бараг болж байв; үдшийн бүрэг бараг.*

БҮРЭГДЭХ I хэтэрхий бүрэг болох.

БҮРЭГДЭХ II бүрэхийн үйлдэгдэх хэв.

БҮРЭГШИХ 1. бүдэгрэх, бүрэг шинжтэй болох; *нүдний хараа бүрэгших;* 2. шилжсэн оюун мэдрэл мунхарч бүрэг бараг болох.

БҮРЭЛГЭНЭ ургамал гашуувтар улаан жимстэй, цагаан цэцэгтэй, бутархаг ургамал, мөн жимсий нь бүрэлзгэнэ гэнэ; *бүрэлгэний төгөл.*

БҮРЭЛГЭХ юмыг хайрлах хэмнэхгүй сүйтгэх, үрэгдүүлэх; *эд хөрөнгийг бүрэлгэн олиггүй авир гаргажээ.*

БҮРЭЛГЭЭЧ бүрэлгэн сүйтгэгч хүн.

БҮРЭЛДҮҮЛЭХ бүрэлдэхийн үйлдүүлэх хэв.

БҮРЭЛДҮҮН бүрэлдэхүүн.

БҮРЭЛДЭХ I ямар нэг юм тогтон буй болгох, бүрдэл болох; *социализмын материал техникийн бааз бүрэлдэн тогтох.*

БҮРЭЛДЭХ II шингэн юмны өтгөрөх; *тараг бүрэлдэх; цус бүрэлдэх.*

БҮРЭЛДЭХҮҮН бүрдэл болсон юм; *намын гишүүдийн бүрэлдэхүүн; төлөөлөгчдийн бүрэлдэхүүн; нийгмийн ангийн бүрэлдэхүүн;* **үгсийн бүрэлдэхүүн** (үгсийн сан); *аршаалы химийн бүрэлдэхүүн.*

БҮРЭН 1. цөм, бүгд, гүйцэд; *бүрэн бүтэн; малгай толгой тоо бүрэн; цөм бүрэн байна; сургуулийг бүрэн төгсөв;* 2. төгс; *бүрэн эрх; бүрэн эрхт улс; бүрэн эрхт төлөөлөгч; бүрэн эрхийнхээ ёсоор; бүрэн төгс эрх чөлөө.*

БҮРЭНХИЙ үдшийн гэгээ тасарч, юм бүрэг бараг үзэгдэх үе; **харанхуй бүрэнхий** хорш.; *бүрэнхийд хэдэн морьтой хүн явж байв.*

БҮРЭНХИЙЛЭХ бүрэнхий болох.

БҮРЭХ I өнгөлөх, гадарлах, бүрхэх; *сандал бүрэх; шүд бүрэх; гэр бүрэх.*

БҮРЭХ II 1. буцламгай халуун усанд хуурай юм хийж, уурыг гадагш гаргахгүй бүгнэж, шимийг буулгах; *нохойн хушуу бүрэх;* 2. халуун бүлээн сүүнд хөрөнгө хийж бүгнэгдүүлэн исгэх; *тараг бүрэх.*

БҮРЭЭ үлээж дуугаргах хөгжмийн зэвсэг; *гуулин бүрээ; дүн бүрээ хамартай, дуран хар нүдтэй* (морины цол); **их бүрээ** (том бүрээ); **бүрээ татах** (бүрээ үлээх); ☆ **бүрээ хорхой** амьтан (хэрэм туурганд наалдан явдаг хальсгай хорхой).

БҮРЭЭДЭХ бүрээ татах дугаргах.

БҮРЭЭС юмны гадуур бүрхэх зүйл; *гэрийн бүрээс; малгайн бүрээс; сандлын бүрээс.*

БҮРЭЭСЛЭХ юмыг бүрээсээр бүрэх.

БҮРЭЭЧ бүрээ татахад чадамгай хүн.

БҮС I 1. гадуур хувцасны бэлхүүс, бүслэхийгээр ороож, бэхлэх уях урт нэхмэлийн зүйл буюу сур; *бүсээ чангалах; суран бүс; бүсэндээ хавчуулах;* 2. дэлхийн бөмбөрцгийн хоёр уртрагийн хоорондох хэсэг газар; дэлхийг уртрагаар 24 бүс буюу зурвас болгон хуваана; 3. дэлхийн бөмбөрцгийн өргөргүүдийн хоорондох цаг уурын ямар нэг зохих зур-

вас болох хэсэг газар; *халуун бүс; сэрүүн бүс;* 4. домен зуухны хэсгийн нэр; *хайлуулах бүс; нүүрстөрөгчөөр халаах бүс;* ☆ **аврах бүс** (усанд живсэн хүний биенд усан дээр тогтооход зориулсан илчүү цагариг).

БҮС II з у р х а й сарны зурхайн ёсны хорин найман одны нэр.

БҮСГҮЙ эмэгтэй хүн; *бүсгүй хүүхэд.*

БҮСЛҮҮЛЭХ 1. бүслэхийн үйлдүүлэх хэв; 2. бүслэгдэх.

БҮСЛҮҮР 1. юмыг тойруулан бэхэлсэн зүйл; *хувингийн бүслүүр; гэрийн бүслүүр;* 2. хил хязгаартай хэсэг зурвас газар бүс.

БҮСЛҮҮРДЭХ бүслүүрээр ороож бэхлэх.

БҮСЛҮҮРЛЭХ бүслүүрдэх.

БҮСЛЭГДЭХ бүслэхийн үйлдэгдэх хэв; *партизан цэрэгт бүслэгдэв.*

БҮСЛЭЛТ ямар нэг юманд эргэн тойрон хүрээлэгдсэн байдал; *дайсны цэргийн бүслэлт эвдэв.*

БҮСЛЭХ 1. бүсийг биедээ ороон бэхлэх, уях; *дээлээ өмсөн, бүсээ бүслэв;* 2. юмыг тойрон хороолох; *дайсны цэргийг бүсэлж байлдах; бүлэг хулгайг бүсэлж барих.*

БҮСРЭГ: **бүсрэг яр** улайлцан барзайж гарах яр.

БҮСТЭЙ эрэгтэй; *бүстэй хүн; бүстэй хүүхэд.*

БҮТҮҮЛЭХ 1. бүтээх, бүтэхийн үйлдүүлэх хэв; 2. битүүлэх, битүү болгох.

БҮТЭЛ бүтэх явц, бүтэмж, *ажил бүтэл муутай байна.*

БҮТЭЛГҮЙ 1. бүтэл муутай; *бүтэлгүй үйл;* 2. бүтэмжгүй, чадвар муутай; *бүтэлгүй хүн.*

БҮТЭЛТЭЙ 1. бүтэхдээ хялбар, бүтэл сайтай; 2. бүтэмж сайтай, чадвар сайтай.

БҮТЭМ бүтмээр төлөвтэй.

БҮТЭМЖ үйл ажлын явц төлөв; *бүтэмжтэй ажил; бүтэмж муутай явдал.*

БҮТЭМЖГҮЙ 1. бүтэхэд бэрхтэй; 2. урагшгүй.

БҮТЭМЖТЭЙ 1. бүтэмж сайтай; 2. урагштай.

БҮТЭН бүрэн, гүйцэд, бүхэл, иж, эвдрээгүй, дутуугүй; *бүтэн найман цаг ажил хийв;* **бүтэн биш** (хагас); *хальтарч ойчиход нүдний шил бүтэн байв* (эвдрээгүй); **нар бүтэн барих** (сүүдэрт бүтнээр халхлагдах); **бүтэн сар** (а. гуч хоногтой сар; б. тэргэл сар); **бүтэн сайн өдөр** (ням гариг); *санасан хэрэг сэтгэлчлэн бүтэх; энэ өдөр унаа бүтэх байх; миний бодож байгаагаар бүтэх эсэхийг сайн мэдэхгүй байна.*

БҮТЭХ I төрөх, үүдэх, болох, гүйцэх, биелэх, боловсрох; *захисан зүйл бүтэх болов уу?*

БҮТЭХ II уур хилэн төрж багтран тачаадах, давчдах; *амьсгал бүтэх; халууцан бүтэж үхэх шахав.*

БҮТЭХ III шарх зэргийн аних, эдгэх, битүүрэх; *миний шарх одооноос бүтэж байна.*

БҮТЭХГҮЙ 1. авсаар болохгүй, бүтэхэд хэцүү; 2. ш и л ж с э н муу, олиггүй; *бүтэхгүй хүн; бүтэхгүй явдал.*

БҮТЭЦ I дотоод байгуулалт; *хэлний бүтэц.*

БҮТЭЦ II бүтэл; *санасан хэрэг бүтэцтэй байна; бүтэц муу.*

БҮТЭШГҮЙ хялбар бүтэхгүй, болшгүй, *бүтэшгүй үйл бүү хий, болохгүй бүтэхгүй хүний үг сургаалд бүү орт!*

БҮТЭЭГДЭХҮҮН бүтээсэн юм; *үйлдвэрийн бүтээгдэхүүн; бүтээгдэхүүний өөрийн өртгийг хямдруулах.*

БҮТЭЭГЧ бүтээдэг.

БҮТЭЭЛ бүтээсэн; *уран бүтээл; үр бүтээлтэй ажиллах.*

БҮТЭЭЛТ бүтээх үйлийн нэр; *бүтээлт хөдөлмөр; үр бүтээлтэй ажил.*

БҮТЭЭЛЧ 1. бүтээх чадвартай, бүтээхдээ сайн; *бүтээлч авьяас;* 2. байгаа юмыг санаачлан дэлгэрүүлж хэрэглэх; *марксизмыг бүтээлчээр хэрэглэх.*

БҮТЭЭЛЭГ юмыг халхлах зүйл; *орны бүтээлэг; ачааны бүтээлэг.*

БҮТЭЭМЖ бүтэж байгаа явц; *ажлын бүтээмж сайн байна.*

БҮТЭЭХ бүтэх I II-ын үйлдүүлэх хэв; *даалгасан ажлыг бүтээх хэрэгтэй; бороо орох нь байна, аргалаа бүтээхийг бод!*

БҮҮ хориглох үг; битгий, үл; *чи бүү яв!; бүү хэл!; бүү сана; бүү мэд; айвал бүү хий, хийвэл бүү ай* х у у ч . .

БҮҮВЭЙ: бүүвэй бүүвэй нялх хүүхдийг нойрсуулахад дуулах аялга үг; *урт насла бүүвэй бүүвэй, удаан жарга бүүвэй бүүвэй;* **бүүвэйн дуу** (бүүвэйлэхэд дуулах дуу); **бүүвэй гүйлс** у р г а м а л (бүйлсний нэг зүйл).

БҮҮВЭЙЛҮҮЛЭХ 1. бүүвэйлэхийн үйлдүүлэх хэв; 2. бүүвэйлэгдэх.

БҮҮВЭЙЛЭГДЭХ бүүвэйлэхийн үйлдэгдэх хэв; *галт тэрэгний хөдөлгөөнд бүүвэйлэгдсээр байгаад унтчихлаа.*

БҮҮВЭЭ бүүвэй.

БҮҮВЭЭЛЭХ хүүхдийг бүүвэй бүүвэй гэж аялан хөдөлгөж нойрсуулах.

БҮҮДГЭР 1. бүдэг, өнгө муутай; *тэнгэр бүүдгэр болов;* 2. шилжсэн сэтгэлд ая эвгүй; *дотор бүүдгэр болох.*

БҮҮДИЙХ бүүдгэр болох; *тэнгэр бүүдийжээ.*

БҮҮР I маш, хамгийн, огт, үүрд; *бүүр сайнаас нь шилэх; бүүр хол газар явах; бүүр явахаа болив;* **бүүр болих** (а. огт болих; б. улам дордох).

БҮҮР II 1. сүрэглэсэн бүлэг, бөөн; *чоныи бүүр; бүүр нохой;* 2. хуйвалдсан хэсэг; *бүүр нохой хүн барьдаг, бүүр хүн хүн барьдаггүй* з ү й р.

БҮҮР III бүүр түүр, нарийн тодорхой биш; *бүүр түүр санагдана.*

БҮҮРГЭН бүүрэг II.

БҮҮРЛҮҮЛЭХ бүүрлэхийн үйлдүүлэх хэв.

БҮҮРЛЭХ сүрэглэн бүлэглэх; *чоно бүүрлэсэн газар байжээ.*

БҮҮРҮҮЛЭХ бүүрэхийн үйлдүүлэх хэв.

БҮҮРЭГ I эмээлийн урьд хойд талын шовгор хавтгай мод; *эмээлийн бүүрэг; бүүрэгнээсээ барин явав.*

БҮҮРЭГ II үнэг, тарвага, хярс зэрэг амьтны бөөс.

БҮҮРЭЛХҮҮЛЭХ бүүрэлхэхийн үйлдүүлэх хэв.

БҮҮРЭЛХЭХ 1. бүлэглэн гадуурхах, хавчих; *та нар битгий бүүрэлхээд бай гэж хэлэв;* 2. бүлэглэн тэмцэж маргалдах.

БҮҮРЭХ бор гөрөөсний дуугарах; *гөрөөс бүүрэх.*

БҮХ бүгд, нийт, хамаг; *бүх дэлхийн шударга хүн төрөлхтөн; бүх ажилчдын цуглаан; бүх улирлын турш; бүх хүчээ дайчлах; бүх цэргийн жанжин; бүх нийтээр гэгээрэн боловсрох; бүх л зуны турш.*

БҮХИЙ 1. байгаа; *энд оршин бүхий амьтан; хадгалагдан бүхий хөрөнгө;* 2. хамаг; *хатан зориг бүхий чадлаараа хайрт монгол ормоо мандуулъя; буй бүхий юмаа гаргав.*

БҮХЭЛ бүтэн, таслан салгаагүй, хуваагаагүй; *бүхэл цай; бүхэл зуутын дэвсгэр; бүхэл мах;* **бүхэл тоо** (хуваагдаагүй тоо); **бүхэл насандаа** (насан туршид).

БҮХЭН нэгбүр, цөм; *хүн бүхэн адилгүй, морь бүхэн жороогүй* з ү й р; *газар бүхнээ; та бүхэнд сонсгоё.*

БҮХЭЭГ нар салхи зэрэг зүйлээс халхалж бүрхүүлэн хийсэн юм; *малын бүхээг; тэрэгний бүхээг.*

БҮЧ 1. юмыг уяж торгоход зориулан хадсан оосор; *малгайн бүч; барилдувчны бүч; бүчийг уях; пионерийн улаан бүч; оосор бүчгүй орд цагаан өргөө байв* ү л г э р э э с; 2. чимэг болгон хадсан унжих зүйл.

БҮЧИГДЭХ бүчихийн үйлдэгдэх хэв.

БҮЧИМДЭХ амьсгал бачуу давч болж, дотор давчдах.

БҮЧИХ хурж шавах; *манай урлагийн төлөөлөгчдийг нисэх онгоцноос буумагц үй олон хүн хүшууран бүчлээ; ялаа бүчих.*

БҮЧЛҮҮЛЭХ бүчлэхийн үйлдүүлэх хэв; *миний хүү малгайгаа бүчлүүл!.*

БҮЧЛЭХ бүчийг уях; *малгай бүчлэх.*

БҮЧҮҮЛЭХ 1. бүчихийн үйлдүүлэх хэв; 2. бүчигдэх.

БҮШҮҮРХҮҮ бүшүүрхэг.

БҮШҮҮРХЭГ бишүүрхэг.

БҮШҮҮРХЭХ бишүүрхэх.

БЭВГЭНЭХ бэвгэр юмны бэвэг бэвэг хөдлөх.

БЭВГЭР дорой, үхээнц байдалтай; *бэвгэр хүүхэд; бэвгэр хурга.*

БЭВИЙЛГЭХ бэвийхийн үйлдүүлэх хэв, бэвийхэд хүргүүлэх.

БЭВИЙХ бэвгэр болох, бэвийн харагдах.

БЭВРЭХ үйл ажилд үхээнц байдал гаргах.

БЭВТНЭХ бэврэх; *бэвтнээд юу ч хийж чадахгүй хүн байна.*

БЭВЭЛЗЭХ бэвгэр юмны бэвэс бэвэс хөдлөх байдал.

БЭГ: бэг баатар амьтан өдөр гадагш ул гаран, бүрий шөнө гардаг уулийн **төрлийн** шувуу; хортон шавьж устгадаг тул ашигтай дархалсан болно.

БЭГТРЭЛ тэвдэл, сандрал.

БЭГТРЭХ гэнэтхэн хэлмэж учраа олохгүй болох; айж *бэгтрэх.*

БЭГТРЭЭ аймхай, сандрамхай.

БЭГТЭР: бэгтэр хуяг даасан цэргийн хуяг.

БЭГЦГЭР туранги бөгөөд махигар бөхгөр юм.

БЭГЦИЙЛГЭХ бэгцийхийн үйлдүүлэх хэв.

БЭГЦИЙХ бэгцгэр болох, бэгцийж харагдах.

БЭГЦЭГ: бэгцэг бэгцэг хийх бэгцгэр юмны үргэлжлэн хөдлөх.

БЭГЦЭГНҮҮЛЭХ бэгцэгнэхийн үйлдүүлэх хэв.

БЭГЦЭГНЭХ бэгцгэр юмны бэгцэг бэгцэг хөдлөх.

БЭГЦЭЛЗЭХ бэгцгэр юмны бэгцэс бэгцэс хөдлөх.

БЭГЦЭС: бэгцэс бэгцэс хийх бэгцгэр юмны байн байн хөдлөх.

БЭДРЭХ эрэх, хайх; *эрэх бэдрэх.*

БЭДҮҮР барсын өөр нэр.

БЭДЭХ хэсэх, тэнэх; *газар газар бэдэх.*

БЭЖИРМЭГ жижиг бэжрүү.

БЭЖИРМЭГТЭХ бэжирмэгтэй болох, бэжирмэг тогтох.

БЭЖРҮҮ юманд бий болсон жижиг бөм ширхэг.

БЭЖРҮҮТЭХ бэжрүүтэй болох, бэжрүү тогтох.

БЭЛ I хөрөнгө; **бэл хөрөнгө** хорш.; *бэл мөнгө; худалдааны бэл; бэл бэнчин.*

БЭЛ II хэт хутга зэргийн юмны зүүх оосрын чимэг; *хэт бэл.*

БЭЛ III уулын хажуугийн шувтрах налуу газар; *уулын бэл; бэл газар.*

БЭЛБЭРХИЙ бэрэвхий.

БЭЛБЭСРЭЛ бэлбэсэрсэн нь; *эмгэнэл бэлбэсрэл; бэлбэсрэл хийх.*

БЭЛБЭСРЭХ эмгэнэлийн ёс гүйцэтгэх; **хуучирсан** эцэг эхэд хамаатан **төрөл болон** ихэс дээдсийг нас барахад тогтоосон хугацаанд цагаан хувцас өмсч үс авахуулахгүй байх, мөн амьтны амь тэвчих зэрэг ёс журам үйлдэх.

БЭЛБЭСЭН I хань нөхрөө үхүүлсэн, эргүй эм; *бэлэвсэн эхнэр.*

БЭЛБЭСЭН II малын дан ганц зүс.

БЭЛДВЭР бэлдсэн юм; *бэлдвэр хоол.*

БЭЛДҮҮЛЭХ бэлдэхийн үйлдүүлэх хэв; *хөдөө авч явах юм бэлдүүлэх хэрэгтэй.*

БЭЛДЭХ бэлэн зэлэн болгох, төхөөрөн зэхэх; *аянд бэлдэх; хоол бэлдэх; худалдахад бэлдэх.*

БЭЛЖИХ бэл хөрөнгөтэй болох.

БЭЛЖҮҮЛЭХ бэлжихийн үйлдүүлэх хэв.

БЭЛЛҮҮЛЭХ бэллэхийн үйлдүүлэх хэв.

БЭЛЛЭХ I уулын бэлээр явах; *бэллэж явах.*

БЭЛЛЭХ II бэл юмтай болох.

БЭЛТГЭГЧ бэлддэг хүн; *хэвлэлд бэлтгэгч; унаа бэлтгэгч.*

БЭЛТГЭЛ 1. бэлдвэр, урьдчилан бэлдсэн юм; *бэлтгэл анги; бэлтгэл ажил; улс төрийн бэлтгэл; бэлтгэл дарга;* 2. бэлтгэн нийлүүлэх юм; *мал бэлтгэл; ноос бэлтгэл; түүхий эдийн бэлтгэл; худалдаа бэлтгэл*; 3. нөөц, нөөцөлсөн юм; *эм бэлтгэл; нөөц бэлтгэл.*

БЭЛТГЭХ бэлэн болгож зэхэх; *шалгалтад сайн бэлтгэх хэрэгтэй; ажилд хэрэглэгдэх зүйлээ урьдаар бэлтгэх нь чухал.*

БЭЛТРЭГ чонын зулзага.

БЭЛТРЭГЛЭХ чонын зулзагалах.

БЭЛХГЭР гэдэс хэвэл будүүн тарган.

БЭЛХИЙЛГЭХ бэлхийхийн үйлдүүлэх хэв; бэлхийхэд хүргүүлэх.

БЭЛХИЙХ бэлхгэр болох, бэлхийн харагдах.

БЭЛХНЭГ бэлхэнцэг.

БЭЛХҮҮС цээж бөгс хоёрын зааг, хоёр бөөрийн орчим газар буюу бүс бүслэх газар; *нарийн бэлхүүстэй.*

БЭЛХЭВЧ бэлхэмж.

БЭЛХЭГНЭХ 1. бэлхгэр юмны бэлхэг бэлхэг хөдлөх; 2. бэлхэнцэглэх.

БЭЛХЭЛЗЭХ бэлхгэр юмны бэлхэс бэлхэс **хийх.**

БЭЛХЭМЖ 1. хүний бэлхэнцгээр өмсөх хувцас; 2. морины эмээл ба тохмын гадуур даран торгох тусгай олом.

БЭЛХЭМЖЛҮҮЛЭХ бэлхэмжлэхийн үйлдүүлэх хэв.

БЭЛХЭМЖЛЭХ бэлхэмж өмсөх.

БЭЛХЭН 1. бэлэн зэлэн байгаа юм; *бэлхэн цай;* 2. бэлэн байна; *хэзээд бэлхэн.*

БЭЛХЭНЦЭГ 1. бэлхүүс орчим газар; 2. бэлхэмж.

БЭЛХЭНЦЭГЛҮҮЛЭХ бэлхэнцэглүүлэхийн үйлдүүлэх хэв.

БЭЛХЭНЦЭГЛЭХ хоёр ханцуйгаа тайлж бэлхүүсээр уях; *бэлхэнцэглэж суугаад хоол идэж байв.*

БЭЛЦГЭР цэлцгэр; **бэлцгэр цэлцгэр** х о р ш.

БЭЛЦИЙХ бэлцгэр болох, бэлцийж харагдах.

БЭЛЦРҮҮ цэврүү, булцруу.

БЭЛЦРҮҮТЭХ бэлцруу тогтох, бэлцрүүтэй болох.

БЭЛЦЭГНҮҮЛЭХ бэлцэгнэхийн үйлдүүлэх хэв.

БЭЛЦЭГНЭХ бэлцгэр юмны бэлцэг бэлцэг хийх.

БЭЛЦЭЛЗЭХ бэлцгэр юмны бэлцэс бэлцэс хийх.

БЭЛЧИР уулзар, уулзвар, нийлбэр; *олон замын бэлчир; голын бэлчир.*

БЭЛЧИРЛЭХ уулзарлах, бэлчир нийлэх.

БЭЛЧИХ 1. амьтны идэшлээр явах; *хонь бэлчих;* 2. тарж явах.

БЭЛЧЭЭР малын идэшлэх газар; *уулын бэлчээр; хөдөө талын бэлчээр; ус бэлчээр таарууулах; өвс бэлчээр.*

БЭЛЧЭЭРЛҮҮЛЭХ бэлчээрлэхийн үйлдүүлэх хэв, бэлчээх, бэлчээрт хариулах.

БЭЛЧЭЭРЛЭХ бэлчээрээр идэшлэх; *тал дүүрэн адуу бэлчээрлэж байв.*

БЭЛЧЭЭХ бэлчихийн үйлдүүлэх хэв; *хонио бэлчээх цаг боллоо.*

БЭЛЭГ I талархлаа илэрхийлж өгөх юм; *бэлэг барих; бэлэг өгөх; бэлэг сэлэг хүргэн очих.*

БЭЛЭГ II ёр; *бэлэг зохирох; бэлэг зохицох; бэлэг зохих.*

БЭЛЭГ III амьтны им өрхтэн; *эрийн бэлэг; эмийн бэлэг; бэлэг эрхтэн;* **бэлгийн бус үржил** (ямар нэг амьтан болон ургамлын биеийн хэсгийг таслан авахад тэр хэсэг нь үржих үржил); *бэлгийн үржил.*

БЭЛЭГ IV тэмдэг, шинж; **бэлэг тэмдэг; бэлэг шинж** х о р ш . .

БЭЛЭГГҮЙ 1. муу ёр; 2. бэлэг муутай; *ясан бэлэггүй үг хэлэв!.*

БЭЛЭГДЭЛ бэлэгшээсэн нь; *бэлэгдэлтэй сайхан тэмдэг байна.*

БЭЛЭГДЭХ 1. бэлэгшээх; 2. төлөгдөх, мэрэглэх.

БЭЛЭГЛҮҮЛЭХ бэлэглэхийн үйлдүүлэх хэв.

БЭЛЭГЛЭХ 1. бэлэг өгөх; *сайхан ном бэлэглэн өгөв;* 2. бэлэг зохиох.

БЭЛЭГТ бэлэгтэй, өлзийт; **бэлэгт бялзуухай** а м ь т а н (хушуу улаан болоод өргөн, бие харавтархан, эрэгчин эмэгчин нэг газар оршин байдаг шувуу); **бэлэгт дардь** (гардийн өөр нэр); **бэлэгт цэцэг** у р г а м а л (модны иш салаа уян, навч зузаан, цэцгийн өнгө зүйл бүр, хүрэн нь нэн сайхан үнэртэй); **бэлэгт гөрөөс** (хилэн гөрөөсний эр).

БЭЛЭГТЭЙ 1. сайн ёр; *баруун чих хангинав, бэлэгтэй юм дуулах нь шиг байна;* 2. бэлэг сайтай; *бэлэгтэй сайхан үгээр ерөөн магтав.*

БЭЛЭГЧ төлөгч, мэрэгч.

БЭЛЭГШЭЭЛГЭХ бэлэгшээхийн үйлдүүлэх хэв.

БЭЛЭГШЭЭХ бэлэгтэйд үзэх.

БЭЛЭН 1. гарт бэлхэн байгаа; *бэлэн зэлэн; бэлэн мөнгө; орон сууц бэлэн;* 2. бэлхэн; *бэлэн боллоо; тариа хадахад бэлэн болов.*

БЭЛЭНХИЙХ бэлтгэн зэхэх.

БЭЛЭНЧ уулгамч.

БЭЛЭНЧЛЭХ I уулгамчлах.

БЭЛЭНЧЛЭХ II бэлэн байгаагаас нь хэрэглэх.

БЭМБИЙ I зовомхой, аймхай, сүрдэмхий.

БЭМБИЙ II хэвийн боов дарахад тохируулан бэлтгэсэн гурил.

БЭМБИЙЛЭХ бэмбий хийх.

БЭМБИЙХ бэмбэгэр болох.

БЭМБЭГНҮҮЛЭХ бэмбэгнэхийн үйлдүүлэх хэв.

БЭМБЭГНЭХ 1. бэмбэгэр юмны бэмбэг **бэмбэг хийх;** 2. айн чичрэх.

БЭМБЭГЭР I зузаан бамбагар.

БЭМБЭГЭР II айх сүрдэх нь хялбархан; *бэмбэгэр хүн.*

БЭМБЭЛЗЭХ бэмбэгэр юмны бэмбэс бэмбэс хийх.

БЭНЧИН бэл, хөрөнгө чинээ; *үүнийг авахад чиний бэнчин хүрэхгүй.*

БЭР I хүүхэд дүү нарын гэргий.

БЭР II 1. ярын гэр хальс; 2. амьтны үр зулзаганы хальс; **бэр цэцэг** у р г а м а л (тал, чулуурхаг хөрстэй газар бас намаг голын хөндийд ургадаг цэцэгт ургамал *уудам манай нутгийн уул талаар өнгийн цэцэг олон, онц л түүний дундаас бэр цэцэг олны сэтгэлд хайртай сайхан).*

БЭРВИЙХ 1. бэрвэгэр болох, хөдөлж ядах; 2. айн хулчийх.

БЭРВЭГНЭХ айсхийн болгоомжлох.

БЭРВЭЛЗЭХ бэрвэгнэх.

БЭРГЭЙ бэргэн; **бэргэй хусам** а м ь т а н (цөцгийтэй адилавтар, зун нуур усанд оршдог, бэргэй хусам гэх шиг дугардаг нэг зүйл шувуу);

БЭРГЭН ахын гэргий.

БЭРЛЭХ I бэр тогтох, бэртэй болох.

БЭРЛЭХ II эмэгтэйчүүд хүндтэй хүмүүст хичээнгүйлэх.

БЭРС 1. шатрын голлох хүчтэн; *бэрсээр шалах;* 2. давуу хүчтэн.

БЭРСҮҮ биед хатуурч тогтсон согог; *бэрсүү тогтох.*

БЭРСҮҮТ бэрсүү бүхий; **бэрсүүт зүрж** у р г а м а л (янз амтат зүржээс ихээхэн, арьс зузаан, жижиг бэрсүүтэй, амт нь түүхий байхдаа хүчтэй, хяруу унасан хойно амттайхан болно).

БЭРСҮҮТҮҮЛЭХ бэрсүүтэхийн үйлдүүлэх хэв.

БЭРСҮҮТЭХ бэрсүү тогтох, бэрсүүтэй болох.

БЭРТЭГЧИН эгэл, доод; *бэртэгчин хүн; бэртэгчин үзэл; бэртэгчин явдал.*

БЭРТЭНГЭ 1. гэм согог болсон газар; *гар хөлийн бэртэнгэ; бэртэнгэ өвдөж байна;* 2. ажил явдалд үхээнц дорой; *бэртэнгэ байдал гаргах.*

БЭРТЭХ I амьтны гэмтэх, хэмхрэх, шархлах.

БЭРТЭХ II бэр тогтох, бэртэй болох.

БЭРТЭЭХ 1. бэртэхийн үйлдүүлэх хэв; 2. бэртэгдэх.

БЭРХ I 1. **хэцүү,** хүчир, хүнд, харгис, догшин; *дайны бэрх цагт; бэрх ажил; бэрх өвчин; эрхийг сурахаар бэрхийг сур* х у у ч .; *баян хүнтэй заргалдах бэрх, баатар хүнтэй барилдах бэрх* х у у ч .; *бэрхийг туулах;* **хүнд бэрх** х о р ш .; *хийх бэрх, байх бэрх;* 2. чадамгай, сурмаг, онцгой, чухаг; *ажилд бэрх хүн; түүний зохиолын найруулга бэрх сайн; тэшүүрээр хурдлах нь бэрх хурдан.*

БЭРХ II дөрвөн шагаагаар наадахад «хонь», «ямаа», «морь», «тэмээ», буух; *бэрх буулгах; дөрвөн бэрх орхих.*

БЭРХДҮҮЛЭХ бэрхдэхийн үйлдүүлэх хэв.

БЭРХДЭХ хэтэрхий бэрх болох.

БЭРХТЭЙ бэрхшээл ихтэй хэцүү; *бэрхтэй замыг туулан өнгөрөв.*

БЭРХТЭХ I бэрхтэй болох, бэрх болох.

БЭРХТЭХ II ихэс ихэд түдэх.

БЭРХШЭЭЛ ярвиг, будлиан, төвөгтэй; *бэрхшээл учрах.*

БЭРХШЭЭЛГЭХ бэрхшээхийн үйлдүүлэх хэв.

БЭРХШЭЭЛТЭЙ бэрхшээл ихтэй; *хүнд бэрхшээлтэй тохиолдовч давах зориг байна.*

БЭРХШЭЭХ халирах, төвөгшөөх, айх, ичингүйрэх; *ажлаас бэрхшээх; бэрхшээхээр хүнд ажил бус; бэрхшээх хэрэг байна уу, чамд?.*

БЭРЧГЭР барчгар, баржгар; **бэрчгэр луугийн нүд** у р г а м а л (иш мод өндөр, жигд ургадаг, бүдүүн нь хоёр хүн тэвэрч хүрэм, жимсний хальс дүгрэгхэн, завсар нь шар ус ихтэй, амттайхан).

БЭРЧИГНЭХ бэрчгэр юмны бэрчиг бэрчиг хийх.

БЭРЧИЙХ бэрчгэр болох.

БЭРЧИЛЗЭХ бэрчгэр юмны бэрчис бэрчис хийх.

БЭРЧЛЭХ бэрийн ёсоор элбэрэх.

БЭРЭВГЭР зориг зүрх муу, үхээнц дорой.

БЭРЭВХИЙ амьтны шилбэ тагалцаг хоёрын уулзуур орчим газар.

БЭРЭЭ жанчихад зориулсан нарийн могойцог мод; *гэвгүйн бэрээ.* ↓

БЭРЭЭДҮҮЛЭХ 1. бэрээдэхийн үйлдүүлэх хэв; 2. бэрээдэгдэх.

БЭРЭЭДЭХ бэрээгээр цохих.

БЭРЭЭМЭГ у р г а м а л улаан будагт өвс, тосонд чанахад будаг нь бууна.

БЭРЭЭСЭЙ жигнэсэн тутрага.

БЭСРЭГ I хоёрын хоорондоос гарсан нь; бэсрэг **нохой** (нохой тайга хоёрын дундаас гарсан).

БЭСРЭГ II 1. багахан; *энэ хүнээс арай бэсрэг;* 2. багын дэргэд торниун.

БЭСРЭГ III үхэр адууны холимог айраг; *бэсрэгийн архи.*

БЭСРЭГДЭХ хэтэрхий бэсрэг болох.

БЭСРЭГЛЭХ 1. бэсрэг болгох; *айраг бэсрэглэх;* 2. хоёр юмыг эвцэлдүүлэх.

БЭТ у р г а м а л нэгэн зүйл жимс; иш мод гүег модны адил, хальсны гадуур нэг зэрэг бүдүүн арьстай, дотроо гуч илүү үр ургадаг, шар ус нь амттайхан, **их уувал согтоно**, хальсаар хувин аяга уур хийнэ.

БЭТЭГ I махчин бус шувууны гүзээний оронд байх сав.

БЭТЭГ II малаас муур нохойд дамжин халдаж, улмаар хүнд халддаг өвчин, ихэнхдээ элгэнд тусна, бэтэг өвчнийг зөвхөн мэс заслалаар эмчилнэ; 2. **мөрөөдлөөс** олох сэтгэлийн өвчин; **бэтэг нь хагарах** (мөрөөдөл нь тавьж тайвшрах).

БЭТЭГРЭХ бэтэг өвчтэй болох.

БЭХ I бичих зурахад хэрэглэгдэх будаг; *бэх зуурах; бэх баалах; заартай бэх.*

БЭХ II бат, бөх, хэврэг биш; *бат бэх цоож хийсэн байна;* **бат бэх х о р ш..**

БЭХДҮҮЛЭХ I бэхдэх I-ийн үйлдүүлэх хэв.

БЭХДҮҮЛЭХ II бэхдэх II-ын үйлдүүлэх хэв.

БЭХДЭХ I бэх түрхэх.

БЭХДЭХ II хэтэрхий бэх болох.

БЭХЖИЛ бэхжих үйлийн нэр; *нэгэнт бэхжил олсон зүйл.*

БЭХЖИХ бэх болох; *манай олсон амжилт өдрөөс өдөрт бэхжиж байна.*

БЭХЖҮҮЛЭХ бэхжихийн үйлдүүлэх хэв; *хөдөө аж ахуйн нэгдлийг аж ахуй-зохион байгуулалтын талаар бэхжүүлэх.*

БЭХЛҮҮЛЭХ бэхлэхийн үйлдүүлэх хэв.

БЭХЛЭЛТ бэхэлсэн нь; **цэрэг дайны бэхлэлт** (дайсны дайралтаас хамгаалж хийсэн хамгаалалт).

БЭХЛЭХ бэх болгох; *үүдээ бэхлэх;* **бэхэлсэн газар** (цэргийн хамгаалалт хийсэн газар).

БЭХЛЭЭ бэхэлсэн нь; *бэхлээ хийх.*

БЭХЛЭЭС бэхэлсэн юм; *бэхлээс сайтай.*

БЭХТ: бэхт болор өнгө тас хар, талстай нэг зүйл болор.

БЭХЭР а м ь т а н хилэн загасны нам, урт нь 125 см. хүнд нь 16 кг. орчим, махыг идшинд хэрэглэдэг нэг зүйл загас.

БЭЭВГЭР яданги, дорой, үхээнц.

БЭЭВИЙЛГЭХ бээвийхийн үйлдүүлэх хэв.

БЭЭВИЙХ бээвгэр болох; *хүйтэнд бээвийсэн байна.*

БЭЭВЭГНҮҮЛЭХ бээвэгнэхийн үйлдүүлэх хэв.

БЭЭВЭГНЭХ бээвгэр юмны бээвэг бээвэг хийх.

БЭЭВЭЛЗЭХ бээвгэр юмны бээвэс бээвэс хийх.

БЭЭЛ манжийн үеийн хэтэрхий дөрвөн хэргэмийн хоёрдугаар зэрэг.

БЭЭЛГЭХ 1. бээхийн үйлдүүлэх хэв; 2. дотроо хорсол зангидах.

БЭЭЛИЙ гарын хамгаалал хувцас; *бээлий хийх; нэхий бээлий;* **бээлийн чинээ** (нялх, бага; *бээлийн чинээ хүүхэд*).

БЭЭМЭЛ 1. бээсэн юм; 2. муу санаатай.

БЭЭМЭР бээж муудсан юм.

БЭЭР I яр шархны идээр, ялзармаг.

БЭЭР II газрын хэмжээ, 8 хөрс газар; *100 бээрийн газар.*

БЭЭРЛЭХ бээртэй болох.

БЭЭРҮҮ бээрэг.

БЭЭРҮҮЛЭХ бээрэхийн үйлдүүлэх хэв.

БЭЭРЭГ даарах бээрэхэд хялбархан, хүйтэнд тэсвэр муутай.

БЭЭРЭГДЭХ бээргийн учир тохиромжгүй болох.

БЭЭРЭХ хүйтэнд даарч биеийн хөдлөл муудах; *даарах бээрэх.*

БЭЭС манжийн үеийн хэтэрхий дөрвөн хэргэмийн гуравдугаар зэрэг.

БЭЭХ 1. юм гутаж муухай үнэр орох; 2. нохойн хэхрэх; *нохой бээх;* 3. муу санаа өвөрлөх; *дотроо бээх.*

БЭЭЦГЭР махигар, туранги; *нэг бээцгэр хүн ирэв.*

БЭЭЦИЙХ бээцгэр болох.

БЭЭЦЭГНЭХ бээцгэр юмны бээцэг бээцэг хийх.

БЭЭЦЭЛЗЭХ бээцгэр юмны бээцэс бээцэс хийх.

БЯД I бие бүдүүн, хүч тарган, чадал сайтай; *бядтай хүн; бядгүй амьтан.*

БЯД II: бяд нугас амьтан хушуу шуумгай, загас барьдаг, мах нялуун учир идэж үл болно, бие бяцхан нэг зүйл нугас.

БЯДУУ болхи, дорой, ухаан мулгуу; *бядуу дорой; бядуу ядуу.*

БЯЛАНГАЧ бялдууч, зусарч, долдой, нийлүүлээч, ялбагай зантай; *зальхай бялангач этгээд.*

БЯЛАНГАЧДАХ хэтэрхий бялангач болох.

БЯЛАНГАЧЛАХ бялдуучлах, бусдын байдалд нийлүүлэн явах, долдгонох.

БЯЛАР бийв ба цартай бишгүүр; *бялар бишгүүр.*

БЯЛАРДАХ бялраар хөгжимдөх.

БЯЛАХ нялах, түрхэх; *тос бялах; шавар бялах.*

БЯЛГАХ бялахад хүргүүлэх.

БЯЛД бүл, чадал, тэнхээ; *бялдтай хүн; бялдтай морь.*

БЯЛДАР хүн амьтны биеийн хийц байдал; **бие бялдар** хорш.; *бие бялдар сайтай.*

БЯЛДАРТАЙ бие бялдар сайхан.

БЯЛДАХ нялж түрхэх; *тос бялдах; цавуу бялдах.*

БЯЛДУУРХАГ бялдуурхах зантай.

БЯЛДУУРХАГЧ бялдуурхах зантай хүн.

БЯЛДУУРХАХ биеэ ялбагайхан болгож хууран инээн бусдад нийлүүлэн явах.

БЯЛДУУРХУУЛАХ бялдуурахын үйлдүүлэх хэв.

БЯЛДУУЧ зусарч, эрх ашгийг хөөж бусдад саймшран нийлүүлэгч; *бялдууч хүн.*

БЯЛДУУЧЛАХ зусардах, нэр ашгийн тул саймшран нийлүүлэн аашлах; *зөв зөв гэж даргаа бялдууч лав; бялдууч лан гүйх; зусардах бялдууч лах.*

БЯЛДУУЧЛУУЛАХ бялдууч лахын үйлдүүлэх хэв.

БЯЛЗУУМАР амьтан хитрүү бялзуухайтай адил, жижигхэн шувуу; толгой нүд ихээхэн.

БЯЛЗУУХАЙ *жижигхэн шувууны нийт нэр; бялзуухайн нам.*

БЯЛТ буугийн гал.

БЯЛТДАХ бялт хийх.

БЯЛУУ I шийдэм.

БЯЛУУ II гурилыг хөөлгөж, ногоо, жимс, мах мэт зүйл хийж хайрсан идээ; *махтай бялуу; байцаатай бялуу.*

БЯЛУУДАХ бялуугаар цохих.

БЯЛУУЛАХ бялахын үйлдүүлэх хэв.

БЯЛУУРАХ өөх тос ихтэй идээг үлэмжхэн идсэнээс шандуурах, зүрхэнд хүрэх; *дотор бялуурах; өөхөнд бялуурах.*

БЯЛУУРУУЛАХ бялуурахын үйлдүүлэх хэв.

БЯЛХААХ бялхахын үйлдүүлэх хэв.

БЯЛХАЙХ бялхгар болох, бялхайн харагдах.

БЯЛХАЛЗАХ бялхгар юмны бялхас бялхас хийх.

БЯЛХАХ дүүрэн болох, элбэг их болох; *сөнд айраг бялхаж байв.*

БЯЛХГАНАХ бялхгар юмны бялхга бялхга хийх.

БЯЛХГАНУУЛАХ бялхганахын үйлдүүлэх хэв.

БЯЛХГАР нялцгар, улцгар.

БЯЛХДАС 1. бялхаж гарсан юм; 2. галт уул дэлбэрэхэд газрын гадрага дээр гарсан хайлмаг чулуулаг; *галт уулын бялхдас.*

БЯЛХМАЛ бялхсан, дүүрсэн; **бялхмал чулуулаг** (галт уул болон газрын ан цаваас гарсан бялхдас).

БЯЛХУУЛАХ 1. бялхахын үйлдүүлэх хэв; 2. бялхаах.

БЯЛЦАЙЛГАХ бялцайхын үйлдүүлэх хэв.

БЯЛЦАЙХ бялцгар болох.

БЯЛЦАЛЗАХ бялцгар юмны бялцас бялцас хөдлөх.

БЯЛЦГАНАХ 1. бялцгар юмны бялцга бялцга хөдлөх; 2. нялцганах.

БЯЛЦГАР нялцгар, нялхгар.

БЯЛЦУУ юмны түгдийн гарсан газар, бургасны салаа, найлзуур, сойхын ишинд ургасан бонхгор юм; *ургамлын бялцуу.*

БЯЛЦУУТАХ шарх сорви, хугарсан булгарсан газарт бялцуу тогтох.

БЯМБА I долоон хоногийн зургадугаар өдөр.

БЯМБА II нарны аймгийн нэг ертөнц.

БЯНТ 1. буугийн гол төмрийн дотоод дахь гурви; *бууны бянт;* 2. дугуй, бинт.

БЯНТЛАХ 1. тойроглон зурах; 2. бянттай болгох.

БЯР тэнхээ тамир; *бяртай бөх; бяртай морь;* **бяр чадал** х о р ш..

БЯРАЛХАГ тэнхээтэй, чадалтай, бяр ихтэй; *бяралхаг эр.*

БЯРАЛХАХ бярандаа эрдэх, хүчдэх.

БЯРАЛХУУ бярархуу.

БЯРАРХАГ бяралхаг.

БЯРАРХУУ бярархаг.

БЯРГҮЙ бяр муутай, чадалгүй; *бяргүй хүн үүнийг яаж өргөх вэ!.*

БЯРДАХ хүчдэх, бяраа гаргах.

БЯРМАГ у р г а м а л навчиндаа хатуухан үстэй, цэцэгтэй, төрөл зүйл 40 шахам, эмэнд хэрэглэдэг ургамал; бярмаг нь хөх буюу ягаан цэцэгтэй, нэг настай ч бий, олон настай ч бий.

БЯРМАН Энэтхэгийн эртний нэгэн овогтон; *бярманы шажин.*

БЯРТАЙ бяр тэнхээ ихтэй.

БЯРУУ хоёр настай үхэр; **бяруун өтөг** (хоёр настай өтөг).

БЯСАА а м ь т а н муу буртаг бүхий гэр суцанд үрждэг хорхой, үнэр муу, хүнийг зуувал зуусан газар нь гурвитан загатнах нь тэсэшгүй хонины үнэрт зайлна; **бясааны хор** (бясаа хорхойг устгах хор); **бясаан цох а м ь т а н** (хөвөн болон хөдөө аж ахуйн ургамалд хортой нэг зүйл бясаа).

БЯСАЛГАГЧ бясалгал хийгч.

БЯСАЛГАЛ сэтгэлд гүнээ бодох, бясалгах нь; *бясалгал үйлдэх.*

БЯСАЛГАЛЧ хянан бодогч, бясалган үйлдэгч.

БЯСАЛГАХ 1. бодож боловсруулах, юмыг олонтаа сэтгэн бодох;2. шажны ёсноо ямар нэгэн үйлийг сэтгэлээр бодон бодож бүтээх.

БЯСАЛГАШГҮЙ бясалгаж болохгүй.

БЯСАЛГУУЛАХ бясалгахын үйлдүүлэх хэв.

БЯСЛАГ сүүг тараг мэтээр ээдүүлэн шүүж, дараа нь шар сүүг шахан гаргаж хийдэг нэг зүйл идээ; *бяслаг шахах.*

БЯЦ хүч нэмэгдүүлэх үг, няц; *бяц цохих; бяц базах.*

БЯЦАРХАЙ 1 .бяцран бутарсан нь; *бяцархай мод;* 2. бяцарсан хэсэг.

БЯЦЛАХ бяцрахын үйлдүүлэх хэв, бяцрахад хүргүүлэх; *өндөг бяцлах.*

БЯЦЛУУЛАХ бяцлахын үйлдүүлэх хэв.

БЯЦРАХ няцрах, бутран хэмхрэх; *бяцарсан ясыг эвлүүлэн боох.*

БЯЦРУУЛАХ бяцрахын үйлдүүлэх хэв.

БЯЦХАН бага, жижиг; *бяцхан хүүхэд; бяцхан сандал;* **бяцхан зэрэг** (улаан нүд өвчин); **бяцхан зэрэг сувилах** (улаан нүд өвчнөөр өвдөх); **бяцхан алтан хундага цэцэг** у р г а м а л (алтан хундага цэцэгтэй адилавтар, жил эцэслэн тэргүүлэгч цэцгийн хамт цэцэглэнэ); **бяцхан хонгор галуу** а м ь т а н (их хонгор галуутай адил боловч бие бяцхан нэг зүйл галуу); **бяцхан доголон ханчир** а м ь т а н (хүзүү толгой харавтархан, улаан бидэртэй, ар жигүүр сүүлийн чандар шаравтархан, хар бидэртэй, зүлэг газар орших шувуу); **бяцхан хархираа шувуу** а м ь т а н (тогорууны намын шувуу, янз тэглийтэй адил, үнсэн өнгөтэй, хүзүү хар, хушуу урт, нүдний зовхинд нижгээд цагаан өрөвлөг бий, биеийн өндөр нэг тохой илүү).

БЯШАЛГАХ шингэн юмыг маш удаан буцалгаж хорхог болгох.

В

В 1. В үсэг, В авиа; 2. гуравдахь, гуравдугаар гэсэн утгаар; *«В»-д дурдсан нь; долоогийн «В» анги;* ☆ **«В» витамин** (усанд уусдаг нэг зүйл витамин).

ВАА I ялзарч гутаж байгаа чийгтэй юман дээр буй болон тогтсон үс мэт өчүүхэн мөөгөнцрүүд; *ваа тогтох.*

ВАА II уурлах, гайхахад хэлэх аялга; *ваа чи яав даа!; ваа хачин юм даа.*

ВААДАГНАХ ваадаңд боох ороох; *хувцас ваадагнах.*

ВААДАГНУУЛАХ 1. ваадагнахын үйлдүүлэх хэв; 2. ваадагнагдах.

ВААДАН юм боож орооход хэрэглэх дөрвөлжин бөс; *ваадаңд боох; дээлийн ваадан; ваадантай юм.*

ВААЛ будаа гурил зэрэг идэшний зүйл чийг авснаас болж тогтсон хөгц мэт ногоовтор юм.

ВААЛАХ будаа гурил зэргийн идэшний зүйл чийг авч ялзран гутах; *гурил ваалах.*

ВААЛУУЛАХ ваалахын үйлдүүлэх хэв.

ВААР 1. нарийн шаврыг түлж хийсэн сав суулга; *айргийн ваар; цэцгийн ваар; шаазан ваарын үйлдвэр;* 2. байшин дээвэрлэхэд хэрэглэх ховхи мэт хэлбэртэй тоосго; *дээврийн ваар;* **дарах ваар** (дээрээс нь даран тавих ваар).

ВААРЛАХ байшингийн дээврийг ваараар өнгөлөх.

ВААРЛУУЛАХ ваарлахын үйлдүүлэх хэв.

ВААРЧ ваар үйлдэхэд мэрэгжсэн хүн.

ВААТАЛ гуйванга шувуу.

ВААТАХ тариа будаа зэрэгт ваал тогтох; *тариа ваатах.*

ВАГОН зорчигчид, ачаа тээвэрлэхэд хэрэглэх төмөр замаар явахад тохирсон дугуй бүхий тэрэг; *суудлын вагон; ачааны вагон.*

ВАЗЕЛИН эмнэлэг, техник зэрэгт хэрэглэх тос; *сайртсан гарт вазелин түрхэх хэрэгтэй.*

ВАККУМ хийг соруулан авсан сав, гаднаас шингэн бодис агаар үл нэвтрэнэ; ваккумд тусгай шинжлэн судлах зүйлийг хийж туршина.

ВАКЦИН халдварт өвчнөөс сэргийлэн хамгаалах тарилга; *годронгийн вакцин.*

ВАЛЬС хөгжмийн аялгуунд хос хосоор, гурван гишгэлийн хэмжээгээр аажимхан эргэх нэг зүйл бүжиг; *вальс хийх.*

ВАЛЮТ ямар нэг улсын мөнгөн тэмдэгтийн нэгж; *алтан валют; валют гуйвуулах.*

ВАН 1. Манж чин улсын үеийн хэтэрхий дөрвөн хэргэмийн нэгдүгээр зэрэг; *ван, гүнгүүдийн зэрэг феодал ноёд;* 2. хааны нэгэн цол; *английн ван;* **вант улс** (засаг төрийн эрхийг ван захиран толгойлсон улс); *ван хаан.*

ВАНДАН I бандан; *вандан ширээ.*

ВАНДАН II нэг зүйл хадаг; *вандан хадаг;* соном хадаг ч гэнэ.

ВАНДУЙ у р г а м а л нэг наст буурцагт ургамал, үр нь тэжээл сайтай; *вандуйгаар мал тэжээх.*

ВАНЧУУ ширүүн ар гарган нэхсэн нэг зүйл панс.

ВАР: вар вар хийх мэлхий зэрэг амьтны дугарах дуун.

ВАРОО (Н) алт мөнгө хайлах жижиг ваар сав; ☆ **вароон соруул дарах** (бумба тавих).

ВАТТ 1. цахилгаан болон эрчим хүчний нэгж, 736 ватт нэг морины хүчтэй тэнцэнэ; 2. цахилгаан энергийн нэгж.

ВАЧИР очир.

ВЕГЕТАТИВ ургал; **вегататив үржил** (ургал үржил); **вегататив эрхтэн** (ургал эрхтэн).

ВЕКСЕЛЬ ямар нэгэн этгээдэд зохих тооны мөнгийг тодорхой хугацаагаар зээлдүүлэх мөнгөний баримт; *вексель олгох; вексель авах.*

ВЕНА бие махбодийн цусыг зүрхэнд юүлэх **гол** судас.

ВИВАНГИРИД 1. ш а ш и н зөн, зөгнөл, иш; **вивангирид өгөх** (иш үзүүлэх); 2. ам өгөх, амлах.

ВИЗ 1. ямар нэгэн улсын хил нэвтрэхэд паспортанд дарах тэмдэг; 2. албаны хүмүүсээс ямар нэг баримт бичигт тэмдэг дарах, гарын үсэг зурах; *тогтоолын төсөлд виз авахуулах.*

ВИНТОВ гол төмөр дотроо горвитой, хол тусгалт буу; *винтовоор буудах; орос винтов.*

ВИРУС халдварт өвчнийг үүсгэгч нян хорхой, ерийн микроскопоор үл үзэгдэх туйлын жижиг нян.

ВИТАМИН 1. хүн, амьтны амьдрал, эрүүл мэндэд чухал ач холбогдолтой зүйлс; *витаминтай жимс*; 2. мөн тийм бодисыг агуулсан эмийн зүйл; *«С» витамин; «Д» витамин.*

ВИТРИН олонд үзүүлэн сонирхуулах үзмэрийн зүйлийг агуулж тавих шилэн нүүртэй сав.

ВИШАЙ шашны ёсонд таван эрхтэнд сэрэгдэх юм; *таван вишай* (мэдрэлийн эрхтэн); *харааны вишай; сонсохын вишай; хүрэлцэхийн вишай.*

ВОКЗАЛ харилцан явах замын томоохон өртөөний буудал; *төмөр замын вокзал; усан онгоцны вокзал.*

ВОЛЕЙБОЛ гар бөмбөг.

ВОЛЬТ цахилгаан хүчдэлийг хэмжих нэгж.

ВОЛЬТМЕТР цахилгаан гүйдлийг хэмжих багаж.

ВОЛЬФРАМ хялбар хайлдаггүй, хатуу, гялгар металл махбод; болд, будаг чийдэнгийн утас үйлдвэрлэхэд хэрэглэнэ.

ВЭ үүрмэг юмны хэмжүүр, арван шиан нэг вэ болно.

Г

Г 1. Г үсэг, Г авиа; 2. дөрөвдүгээр дөрөвдөх гэсэн утга; *«Г»-д дурьдсан зүйл; тавын «Г» анги.*

ГА талбайн хэмжээ, 10000 дөрвөлжин метр; *нэг га газраас авах ургацын хэмжээ; га тутамд оногдох үр.*

ГАА I у р г а м а л халуун оронд ургадаг бутархаг ургамал, үндсий нь авч юм амтлахад хэрэглэнэ; *цагаан гаа; улаан гаа; бор гаа.*

ГАА II гааж, хэл; *хувцсандаа гаатай.*

ГААГА 1. хэрээ тахиа зэргийн дуугарах дууны аялга; *гаага гаага дуугарах;* 2. нялх хүүхдийн, юмыг сонирхон баясч хөөрсөхөд гаргах аялга; *миний хүү юунд баясч гаага гаага гэж хөөрсөв.*

ГААГАЛАХ гаага гаага гэж дуугарах; *усны шувуу гаагалж байв.*

ГААГАЛУУЛАХ гаагалахын үйлдүүлэх хэв.

ГААЖ гаа, гооч, авхаалж.

ГААЖЛАХ гаажтай зан байдал гаргах.

ГААЖТАЙ 1. гаатай; 2. сэргэлэн, авхаалжтай; 3. гоочтой, оотой; *ямар гаажтай амьтан бэ?*

ГААЛИЛАХ гааль авах, гааль хураах.

ГААЛЬ I хил хязгаар нэвтрүүлж гадаадад гаргах, дотоодод оруулах бараа таваараас авах татвар; *гааль авах;* **гааль түрээс; гааль татвар** х о р ш.; 2 .мөн ажлыг эрхэлсэн албан газар; *гааль дээр ирэв;* **гаалийн хороо** (гааль хураах хэргийг эрхлэх газар).

ГААНС (АН) амны тамхи нэрж татах хэрэгсэл: **гаанс бургуйдах** (бохий нь цэвэрлэх); **гаанс тамхи төхөөрөх** (тамхи татах хэрэгсэл бэлтгэх); **гаансны толгой** (тамхи нэрэх хэсэг); **гаансны мод** (нарийн шилбэ); **гаансны соруул** (аманд зуух хэсэг); **гаансны соёо** (сэтгүүр); **гаансны цохиур** (тамхины үнсийг цохиж гаргах хэрэгсэл); **гаансны бохь** (гаансны дотор тогтсон наалдаа зүйл).

ГААРАМБА шажны ёсны таван ухаанд мэрэгших анги, мөн ангид суралцаж байгаа хүн.

ГААРАХ улам нэмэгдэх, хэтрэх, дортох; *хэлэх тусам гаарах; хориглох тусам гаарах; салхин гаарах.*

ГААРУУЛАХ гаарахын үйлдүүлэх хэв; гаарахад хүргүүлэх.

ГААТАЙ I 1. юмыг хайрлах гамнахыг мэдэхгүй арангатай хүн; *дээлдээ гаатай; гуталдаа гаатай хүүхэд;* 2. гаажтай; авхаалжтай.

ГААТАЙ II гаагаар амталсан юм; *гаатай чихэр.*

ГАВ I 1. хатуувтар юманд гарсан ан цав; *шаазангийн гав*; **ан гав**; **гав цав** х о р ш.. ᠭᠠᠪ

ГАВ II урьдын цагт ялт хүний хоёр гарын бугуйгаар холбож агдлах төмөр хэрэглэл; *гарт нь гав торгож, хүзүүнд нь дөнгө өмсгө.*

ГАВ III эв зүй, эе эв, арга, учир, зүй зохис; *эв гавы нь олбол гайгүй.*

ГАВ IV: **гав шав** гавшгай шаламгай, хөнгөн хөдөлгөөнтэй; *гав шав хийсэн эр; ажилд гав шав хөдөлдөг хүн.* ᠭᠠᠪ

ГАВ V: **гав ганц** цорын ганц.

ГАВАЛ 1. хүний толгойн ясны дээд хэсэг; 2. адгуус амьтны толгойн оройн хэсэг. ᠭᠠᠪᠠᠯ

ГАВАР I үнэгний зулзага. ᠭᠠᠪᠠᠷ

ГАВАР II онцгой, хүчтэй үнэртэй талст тунгалаг бодис; эмнэлэг, техникт хэрэглэнэ; **гаврын тос** (гаврын модноос авдаг тос; зүрхний ажиллагааг сайжруулахад хэрэглэнэ): **гаврын мод** у р г а м а л (20—50 метр өндөр, диаметраараа 2.5 метр хүрдэг мөнх ногоон мод, навч нь хатуувтар бөх, цагаавтар цэцэгтэй ,үнэр анхилам сайхан. модны бүх хэсэгт гаврын тос бий); **гаврын цэцэг** (мөн модонд ургадаг цэцэг). ᠭᠠᠪᠠᠷ • ᠭᠠᠪᠠᠷ

ГАВЖ буддын шажны судрын аймаг номлолд мэрэгжсэн хүнд олгох зэрэг. ᠭᠠᠪᠵᠠ • ᠭᠠᠪᠵᠠ

ГАВИА гавь. ᠭᠠᠪᠢᠠ

ГАВИАГҮЙ 1. гавихгүй, олигтой биш, ялигүй, ялихгүй, ялимгүй; *гавиагүй хүн шүү дээ;* 2. ахиагүй, дөхөөгүй; *би сурлагын хувьд гавиагүй байна; тэр ажилдаа дадаж гавиагүй шүү.* ᠭᠠᠪᠢᠠ ᠶ ᠭᠦᠢ

ГАВИАТАЙ гавьтай биш, олиг муутай, яльтай, бага; *миний цуглуулсан жимс гавиатай юм биш.* ᠭᠠᠪᠢᠠ ᠶ ᠪᠠᠭ

ГАВИГҮЙ санасанд хүрэхгүй, тэнцэхгүй; *тэр чинь гавигүй хүн байгаа юм.* ᠭᠠᠪᠢ ᠭᠦᠢ

ГАВИР у р г а м а л цагаан буюу шар цэцэгтэй, зузаавтар том навчтай, олон наст бутархаг ургамал, хэд хэдэн төрөл зүйл буй. ᠭᠠᠪᠢᠷ

ГАВИХ ялих, шалих, юмыг басамжлан чамлахад хэрэглэнэ; *юу гавих вэ; энэ ч гавихгүй юм байна.* ᠭᠠᠪᠢᠬ

ГАВИХГҮЙ тийм сайн биш, базаахгүй, ялихгүй; *гавихгүй морь байна; гавихгүй хэрэг болов.* ᠭᠠᠪᠢᠬᠠ ᠭᠦᠢ

ГАВТАХ ан гав гарах, гав суух; *газар гавтах; толь гавтах.* ᠭᠠᠪᠲᠠᠬ

ГАВТУУЛАХ гавтахын үйлдүүлэх хэв. ᠭᠠᠪᠲᠠᠭᠤᠯᠬᠤ

ГАВХИЙХ гавшгай шаламгай ажиллах; *гавхийсэн ажилтан гав шавхийсэн хүн.* ᠭᠠᠪᠬᠢᠶᠠ

ГАВШГАЙ үйл явдалд түргэн хөдөлгөөнтэй; **гавшгай шаламгай** х о р ш.; *гавшгай бригад; гавшгай ажилчин.* ᠭᠠᠪᠰᠢᠭᠠᠢ

ГАВШГАЙЛАХ 1. үйл явдалд гавшгай чадвар гарган ажиллах; *гавшгайлан ажиллах;* 2. яарах, түргэлэх; *морьт цэрэг гавшгайлан явсаар байв.* ᠭᠠᠪᠰᠢᠭᠠᠢᠯᠠᠬ

ГАВШГАЙЛУУЛАХ гавшгайлахын үйлдүүлэх хэв. ᠭᠠᠪᠰᠢᠭᠠᠢᠯᠠᠭᠤᠯᠬᠤ

ГАВШГАЙЧУУД олон гавшгай хүмүүс; *үйлдвэрийн гавшгайчууд.* ᠭᠠᠪᠰᠢᠭᠠᠢᠴᠤᠤᠳ

ГАВЬ горь, горьдлого; *гавьтай сайн эд биш гавигүй муу юм;* гавиа ч гэнэ. ᠭᠠᠪᠢ

ГАВЬТАЙ олигтой биш, өөдтэй биш, элбэг биш; *гавьтай ч эд биш; гавьтай юм алга.* ᠭᠠᠪᠢᠲᠠᠢ

ГАВЬЯА улс нийгмийн үйл хэргийн төлөө чармайн зүтгэж бүтээсэн туст үйл; **гавьяа зүтгэл** х о р ш.; **гавьяа байгуулах** (гавьяа бүхий ажил бүтээх); **гавьяаны одон** (шагналын тэмдэг; *хөдөлмөрийн гавьяаны одон).* ᠭᠠᠪᠢᠠ ᠶ

ГАВЬЯАТ гавьяа байгуулсан, гавьяа бүхий; *гавьяат зүтгэлтэн; гавьяат жүжигчин; гавьяат үйл; гавьяат багш; гавьяат зоотехник.* ᠭᠠᠪᠢᠠᠲᠤ

ГАВЬЯАТАН гавьяа бүхий хүмүүс; *алдар гавьяатан.* ᠭᠠᠪᠢᠠᠲᠠᠨ

ГАГАГАР хэвийн жишээнээс урагш өнгийсөн буюу шулуун урт, эсвэл уртхан бөгөөд гандгар юм; *гагагар хүзүүтэй амьтан; гагагар сайхан уурга; гагагар нуруутай хүн.* ᠭᠠᠭᠠᠭᠠᠷ • ᠭᠠᠭᠠᠭᠠᠷ

ГАГАГАРДАХ хэтэрхий гагагар болох. ᠭᠠᠭᠠᠭᠠᠷᠳᠠᠬ

ГАГАГАРХАН баахан гагагар; *гагагархан хүзүүтэй тэмээ.* ᠭᠠᠭᠠᠭᠠᠷᠬᠠᠨ

ГАГАДАЙ у р г а м а л бургасны навчаас охорхон навчтай, иш нь зэллэж, бут бутаар ургах нэгэн зүйл өвс; гуа дарж иднэ ᠭᠠᠭᠠᠳᠠᠢ

ГАГАЙ эцгийн эгч, охин дүү нар; **гагай эгч** (авга эгч). ᠭᠠᠭᠠᠢ

ГАГАЛ хэлбэр аруртай тэстэй, нимгэн боровтор хальстай, амт халуун нэг зүйл ур. ᠭᠠᠭᠠᠯ

ГАГАЛЗАХ 1. хүний зүг хэлэлцэж чадахгүй ам ангалзах буюу идэхэд залгиж чадахгүй тээглэх; 2. өлсгөлөнд гүйцэгдэж гуранга-тах. ᠭᠠᠭᠠᠯᠵᠠᠬ

ГАГАР: гагар шүгүр юманд хөнгөмсөг гавшгай, хийх үйлдэх юманд бусдыг түлхлэхгүй уриалган бүтээчихдэг; *гагар шүгүр хүн шүү.*

ГАГНАА гагнаас; *энэ лааз гагнаатай юм.*

ГАГНААДАС гагнаас; *гагнаадсаараа салах.*

ГАГНААС ямар нэгэн юмны гагнасан газар; *халуун гагнаас; хүйтэн гагнаас; цахилгаан гагнаас.*

ГАГНАГДАХ гагнахын үйлдэгдэх хэв; *зөвлөлт-монголын ард түмний зоригт хөвгүүдийн цусаар гагнагдсан бат нөхөрлөл.*

ГАГНАЛТ гагнах үйлийн нэр; *гагналт нь муу байна.*

ГАГНАМАЛ гагнаж хийсэн юм.

ГАГНАХ 1. төмөрлөгийн эвийг нийлүүлэн гагнуур тавих; 2. шилжсэн ямар нэгэн юмыг холбож бат бэх болгох; **гагнах эм** (гагнуурт хэрэглэх тунсаа буюу исгэлэн хүчил, давирхай зэрэг юм).

ГАГНУУЛАХ 1. гагнахын үйлдүүлэх хэв; 2. гагнагдах.

ГАГНУУР 1. төмөрлөгийн зүйлийг гагнахад хэрэглэгддэг алт, мөнгө, төмөр, тугалга мэт зүйл; *гагнуурын хэрэглэл; гагнуурын алх;* 2. гагнаас.

ГАГНУУРЧ гагнах мэрэгжилтэй хүн.

ГАГУЙХ гагагар болох; *их замаар тэмээн жин гагуйж айсуй.*

ГАГЦААР ижил ханигүй, ганц; **гагц гагцаар** (нэг нэгээр).

ГАГЦААРДАХ хань хамсаагүй гагцаарын учир мөхөсдөх.

ГАГЦААРДУУЛАХ гагцаардахын үйлдүүлэх хэв.

ГАГЦААРЛАХ юмыг гагцаар эзэмшин эзлэх.

ГАГЦДАХ гагцаардах.

ГАГЦХҮҮ зөвхөн; *гагцхүү миний энд байгаа юм.*

ГАДАА 1. дотоодод биш, гадна, *гэрийн гадаа; хашааны гадаа; гадаа хүлээж бай!* 2. хөдөө, хээр; *хөдөө гадаа; хээр гадаа;* **гадаа гарах** (гадагш гарах); *хөлийн хумс нь хөдөө тийшээ, гарын хумс нь гадаа тийшээ үлгэр;* 3. энүүхэн, ойрхон; *тэднийх эндээс гадаатай адил байна;* 4. гадаа тал; *дэвтрийн гадаа юм бичиж болохгүй; байшингийн гадаа талыг будах хэрэгтэй.*

ГАДААД дотоод гэдгийн эсрэг утга; 1. гаднах өнгө үзэгдэл; *гадаад хэлбэр; гадаад байдал;* 2. зах хязгаараар оршдог; **гадаад далай** (дэлхийн бөмбөрцгийн хуурай газруудын гадаад этгээдээр үргэлжлэн тогтсон ус: Номхон дөлгөөн гадаад далай, Энэтхэгийн гадаад далай, Атлантигийн гадаад далай); *гадаад хязгаар; гадаад тийш;* 3. өөрийн биш, харь; *гадаад улс; гадаад хүн; гадаад эд; гадаадын харьяат; гадаад хэл; гадаад хэлний багш;* 4. харьтай харьцах; *гадаад яам; гадаад худалдаа; гадаад харилцаа; гадаад бодлого; гадаадын байдал;* 5. гадна байдаг; **гадаад энэр хормой** (дээл хувцасны дотоод энгэрийн дээгүүр давхарлан зөрж байдаг товч торгомж хадсан нэгэн бие).

ГАДААЛАХ 1. гадаа түр гарах; **хурал гадаалах** (түр завсарлах); 2. хүндэтгэлтэй хүний бие засах.

ГАДААЛУУЛАХ гадаалахын үйлдүүлэх хэв.

ГАДАГШ дотогш гэдгийн эсрэг утга; дотор байсан юм гадна тийш болох; **гадагш гарах** (гадаа гарах); *гадагш болох; гадагш хандах;* **гадагш өмсөх** (үст хувцасны үсийг гадагш харуулан өмсөх); **гадагш гаргах** (а. дотор байсан юмыг гадна гаргах; б. гадаад улсад юм гаргах).

ГАДАГШДАХ хэвийн хэмжээнээс хэтэрхий гадагш болох.

ГАДАГШЛАХ дотор байсан юм гадна гарах, гадагш болох; *өвчний хор гадагшлав.*

ГАДАГШЛУУЛАХ гадагшлахын үйлдүүлэх хэв.

ГАДАГШЛУУР гадагш болгодог юм; *гадагшлуур булчин.*

ГАДАЙЛГАХ гадайхын үйлдүүлэх хэв.

ГАДАЙХ юмны хоёр этгээд таталдаж дээш өргөгдөх.

ГАДАР I төмөрлөгөөр хийсэн түмпэн сав; *нүүр угаах гадар; гурил зуурах гадар.*

ГАДАР II дотор гэдгийн эсрэг утга; юмны гадна талд хам байгаа юм; *дээлийн гадар; дэвтрийн гадар; гадар мах; гадар халим; гадар өөх;* **гадар төрх** (гаднах байдал).

ГАДАРГА гадаад буюу өнгөн тал; *дэлхийн гадарга; газрын гадарга; хөрсний гадарга; уулын гадарга.*

ГАДАРГУУ гадарга; *дэлхийн гадаргуу;* **хөрсний гадаргуугийн үе** (хөрсний өнгөн давхарга).

ГАДАРЛАХ I юманд гадар хийх, өнгөлөх; *даалимбаар гадарлах; будгаар гадарлах; шавраар гадарлах.*

ГАДАРЛАХ II юмны байдал төлөвийг төсөөлөн мэдэх; *тэр хэргийн байдлыг би гадарласан; битүүгээр гадарлаж л байна.*

ГАДАРЛУУЛАХ 1. гадарлахын үйлдүүлэх хэв; 2. гадарлагдах.

ГАДАС юмыг торгох тогтооход хэрэглэх нэгэн үзүүрийг шовхлон хийсэн хэрэглэл, төмөр модоор хийнэ; *асар майхны гадас; зэл уяаны гадас;* **гадас шаах** (гадсыг шигтгэн оруулах); **алтан гадас од** (бага долоон өвгөний ордны нэг тод од, алтан гадас од чанх хойт зүгийг заана); **алтан гадас одон** (улс төрд гавьяа байгуулагсдад шагнах нэг зүйл одон).

ГАДАСДАХ 1. юманд гадас шаах; 2. юмыг гадсаар дэлдэх.

ГАДАСДУУЛАХ гадасдахын үйлдүүлэх хэв.

ГАДАСЛАХ гадас шааж торгох.

ГАДАСЛУУЛАХ гадаслахын үйлдүүлэх хэв.

ГАДВАЛЗАХ хүчин хүрэхгүй нуруу автасхийн явах.

ГАДИЛ у р г а м а л халуун оронд ургадаг, олон наст бутархаг өндөр ургамал, мөн үрийг гадил гэнэ; жимс нь гонзгой махир, идэхэд зөөлөн бөгөөд амттайхан, тэжээлтэй.

ГАДИР у р г а м а л 1,5—5 метр өндөр мод; **гадирын цэцэг** (гадирын модонд ургадаг ягаавтар цэцэг); **гадирын жимс** (гадирын модонд ургадаг том жимс, түүхий байхдаа амт гашуун, болсны дараа амттайхан, гадирын жимсээр чанамал хийх буюу архи нэрнэ).

ГАДИРАХ 1. юмны хоёр этгээд дээш татагдаж өргөгдөх; *дээлийн ташаа гадирах;* 2. атирах.

ГАДНА дотно гэдгийн эсрэг утга; 1. дотор биш; *гэрийн гадна; хотын гадна; гаднаас аргал аваад ир!; гадна байя;* 2. гадаа байдал; *гадна үзэсгэлэнтэй; гадна байдал нь ижил; гаднаас нь харвал үзэмжтэй;* 3. зорьсон тухайлснаас ангид; *үүнээс гадна; түүнээс гадна;* 4. дэргэд, ойр; *гаднаа ирнэ; гаднаа байна;* 5. өвөр, харь; *гаднаас ирсэн зочин; гаднын хүнийг ад үзэж болохгүй.*

ГАДНАХЬ гадна оршин буй, эргэн тойрон; *гэрийн гаднахь ямаа үргээ!; хилийн гаднахь; гаднахь байдал.*

ГАДУУР дотуур гэдгийн эсрэг утга; 1. гадаа талаар хэрэглэх юм; *гадуур хавцас; гадуур бүрээс;* 2. ойр дэргэдүүрх; *гэрийн гадуур; хотын гадуур;* 3. үл дотнолох; *гадуур үзэх; гадуур санах;* 4. ангид, гажуу; *ёсноос гадуур; заншлаас гадуур;* 5. ш и л ж с э н гадаа явах сэлгүүцэх; *гадуур явах; гадуур гарах; гадуур их явсан хүн; гадуур зугаалах.*

ГАДУУРЛАХ бусдыг үл дотнолон шоовдорлож гадуурхан үзэх.

ГАДУУРХАХ гадуучлах, гадуур болгон үзэх; *гадуурхан үзэх.*

ГАДУУРХИ 1. гадна талаар байгаа юм; *гадуурхи хальс; гадуурхи бүрээс;* 2. дэргэдүүр шадар байгаа юм; *гадуурхи мал; гадуурхи аргал.*

ГАДУУРХУУЛАХ 1. гадуурхахын үйлдүүлэх хэв; 2. гадуурхагдах.

ГАДУУРЧЛАХ гадуурлах; *нүдний нуух, шүдний мах мэт гадуурчилж байв.*

ГАЖ тэс өвөр, ижил ханигүй, этгээд; *гаж зан; гаж явдал; гаж өвөр; гаж буруу.*

ГАЖАА I хэвийн байдлаас гажиж эвгүй болсон; *цонхны гажаа улам нэмэгдээд байна; тэрэгний гажаа засраагүй бололлой; гажаагий нь гаргахгүй бол хааж болохгүй хаалга.*

ГАЖАА II өнгө бор шарга, дотор цагаан, эхүүн халуувтар амттай нэг зүйл үндэс, эмэнд орно.

ГАЖААС гажаа, гажиг; *гажаас нь гараагүй байна.*

ГАЖААХ гажуулах; *энэ модыг гажааж болохгүй.*

ГАЖИГ 1. шулуун шугам хэвийн хэмжээнээс хазайж муруйсан нь; *модны гажиг гаргах;* **соронзон гажиг** (дэлхийн соронзон талбайнуудын хэвийн хэмжээнээс илүү дутуу болсон нь); *төмрийн хүдэртэй газар, соронзон гажигтай байдаг;* 2. согог, гэм; *би нэг гажигтай болжээ, дандаа толгой өвддөг болов.*

ГАЖИХ 1. юманд гажиг сууж хэвийн хэмжээнээс өөр болох; *самбар гажих; ширээ гажих;* 2. хүний биеийн ямар нэгэн эрхтэн хэвийн байрнаас хөдлөх; *тархи гажих; хүүхэд гажих;* 3. зөрөх, зөрчих, хазайх, муруйх, *ам гажих; зам гажих; хууль гажих.*

ГАЖУУ 1. санаа явдал тохирохгүй буюу зан авир зөрүүд; *гажуу зан; гажуу зөрүүд;* 2. тойруу буюу муруй зам; *гажуу зам; тойруу гажуу;* 3. баримталбал зохих төв ёсноос зөрүү

юм; *гажуу суртал; ёсноос гажуу; дүрмээс гажуу;* **зөрүү гажуу** хорш.; *буруу гажуу; гажуу үг хэлэх.*

ГАЖУУД гажуу, этгээд; *гажууд зан гаргах; гажууд мал; дүрмээс гажууд хэрэг үйлдсэн хүн.*

ГАЖУУДАХ гажуу болох; *хэв журмаас гажуудах; утга нь эх бичгээс гажуудсан байна.*

ГАЖУУДУУЛАХ гажуудахын үйлдүүлэх хэв; *нийтийн хэв журам гажуудуулах.*

ГАЖУУЛАХ гажихын үйлдүүлэх хэв; гажихад хүргүүлэх.

ГАЖУУРХАХ гажуу буруу зан байдал гарган явах.

ГАЗАР I 1. шороо, хөрс, дэлхий; **газар ухах** (шороо малтах); **газар хагалах** (үр тариалахын тул хөрсийг сэндийлэн урвуулах); **газар хагалагч** (газар хагалахад мэрэгжсэн хүн); **газар услах** (а. хөрсийг чийглэн норгох; б. тариалангийн газар суваг татаж ус оруулах); **тариалангийн газар** (а. тарина ногоо тарихаар бэлтгэн боловсруулсан хөрс; б. тарина ногоо нэгэнт тарьсан хөрс); **газар ангах** (хөрс шороо чийгээр дутаж хуурайших); **хар газар** (цасгүй хөрс); **хадлангийн газар** (хадаж өвс авах талбар); **атар газар** (огт тариа тарьж байгаагүй газар); **атаржсан газар** (тариа тариагүй удаж зэрлэгшсэн хөрс); **хуурай газар** (чийггүй хөрс); **газар өврөх** (бороонд тогтсон шавар балчиг эвэрч хуурай болох); **газар нэмүүлэх** (хөрс зөөлрөн дэвтэх); **газар гариалан** (тариалангийн ажил); **газар авах** (а. хэсэг газрыг өөрийн болгон авах; б. архаг өвчин зэрэг юмны хүндрэн даамжрах); **газар өгөх** (а. хэсэг газрыг нөгөө этгээдэд шилжүүлэн өгөх; б. уралдах зэрэгт улам улмаар хурдлан өмнө явснаа гүйцэх); **газар түрээслэх** (газрыг түр хугацаанд тогтоосон үнэ төлбөртэй хэрэглүүлэх); **газар тариалангийн шинэтгэл** (газар тариаланг помещикийн гараас авч улсын болгоод бага газартай болон огт газаргүй тариачинд олгох); **газар дорхи** (газрын хөрсөн дор орших; *газар дорхи зам; газар дорхи ус; газар дорхи баялаг);* **газар дээрх** (газрын хөрсөн дээр орших; *газар дээрх нүүрс; газар дээрх ургамал);* **газрын хөрс** (дэлхийн шороон бүрхэвчийн дээд давхрага; *хар хөрстэй газар);* **газар савах** (юмаар газар гуядах); **газар хөдлөх** (газрын хөрс давхарга хүчтэй доргин хөдлөх); **газар хагарах** (газар антан салж ангайх); **газар дэлхий** (нарны аймгийн гуравдахь ертөнц); **газар дээр** (ертөнц дээр; *газар дээр байгаа ганц хүүдээ авсан юм);* 2. орших нутаг; **газар нутаг, газар орон** хорш.; **суурин газар** (хүн амын суурьшин суусан хот, тосгон, гацаа); **хөл ихтэй газар; хөлтэй газар** (олон хүний үймэлцсэн газар); **буйд газар** (хүн амьтангүй зэлүүд газар); **аглаг газар** (хүн амьтангүй бөглүү газар); **зайдуу газар** (алс хол газар); **хоногийн газар** (өдөр шөнө хоёр явж хүрэх хэмжээтэй газар); **өдөрчийн газар** (нэг өдөр явж хүрэх газар); **газар гэр** (газар ухаж хийсэн орон байр); **газар дээр нь шалгах** (хэрэг явдлыг нутаг орчинд нь шалгах); **газар сайгүй** (хааяагүй, энд тэндгүй); **газар газрын** (олон газар, энд тэнд; *газар газрын хүн, газар газар явсан);* **газар бүр** (газар сайгүй); **уулархаг газар** (их уултай газар); **нам газар** (далайн түвшнээс дээш 200 м. хэтрэхгүй өргөгдсөн газар); *хашин моринд газар хол, харамч хүнд нөхөр хол* хууч.; **газар судлал** (дэлхийн үүсэл, хөгжил, тогтцыг судлах ухаан); **түүхэн газар судлал** (дэлхийн хөгжил, тогтцын түүхийг судлах ухаан); **газар судлалч** (газар судлахад мэрэгжсэн хүн); **газрын эзэн** (а. газар эзэмшигчид, б. хуучирсан шашны ёсонд уул усны эзэн); **газрын эзэн суулгах** хуучирсан (хүний өвчин тасрахгүй, мал тогтохгүй бол бөө залж, газрын эзэн лус савдгийг «ирүүлэх» арга үйлдүүлэх); **газрын юм** хуучирсан (буруу хандсан толгойгүй хатиг); **газрын давирхай** (газраас нэвчиж гарах давирхайлаг хар тос; зам, гудамж, гишгүүр зэргийг цардахад хэрэглэнэ); **газрын оньс** (газрын судал); **газрын гадарга** (газрын гадаад өнгөн байдал); **газрын мухар** (хол бөглүү; *газрын мухарт нутагладаг айл);* **газрын бордоо** (тарих газрыг бордох юм); **газрын баялаг** (газрын дээр дор орших хэрэгтэй юм бүхэн); **газрын алам** (газарт гарсан их нүх, ан, цав); **газрын царцдас** (газрын чулуун бүрхэвч); **газрын манан** (газар дээр суунагласан явган манан); **газар мандал** (дэлхий ертөнцийн бүтсэн бүрхэвч, агаар мандал, шим мандал, усан мандал, чулуун мандал мөн цул (хүнд) мандал цөм орно); **газрын бөөс** (навч идэж амьдардаг жижиг амьтны еренхий нэр, ихэнхдээ туршуултай, хойт хөл урт, харайж явдаг амьтан, төрөл зүйл олон); **газрын өтгө** амьтан (эр шар маахай); **газрын барс** амьтан (барстай адил боловч бие бага, бидэртэй); **газар улаагана** ургамал (ой модтой газар ургадаг нэг зүйл олон наст ургамал, жимс улаан, дотроо ястай).

ГАЗАР II 1. зарим төвлөрсөн албан байгууллага; *засгийн газар; хэрэг эрхлэх газар;*

удирдах газар; ерөнхий газар; цагдан сэргийлэх газар; хэвлэлийн газар; амралтын газар; албан газрын дарга нар; албан үйлдвэрийн газрын орон тоо; 2. юмыг тусгайлан заахад хэрэглэнэ; *энэ газар; тэр газар; өвчтэй газар; орох газар; гарах газар; хойт газар; суух газар.*

ГАЗАР III уртын хэмжээ, 360 алд буюу 576 метр.

ГАЗАРГҮЙ 1. орших хоргодох орон зайгүй; *багтах газаргүй; далдлах газаргүй;* 2. үнэнд гүйцэгдэх, мухардах, чиндээ тулах; *хэлэх газаргүй; нааш харах газаргүй; явах газаргүй;* 3. хэрэггүй; *айх газаргүй; үгүй гэх газаргүй;* 4. ёсгүй, учиргүй; *алга болох газаргүй; мэдэхгүй байх газаргүй.*

ГАЗАРДАХ 1. ямар нэгэн юм газарт тулж хүрэх; *нисэх онгоц газардав; энэ бөхийн өвдөг нь газардсан байна;* 2. хүн элдвээр ядарч доошлох, арга мухардах; *намайг арчлах хүнгүй учир аргагүй газардаж явна би; би үүнийг аргадсаар байгаад газардав.*

ГАЗАРДАХГҮЙ алзахгүй; *үүнийг уншаад шалгалтанд ороход газардахгүй; би хаа ч газардахгүй гэж бодож байна.*

ГАЗАРДУУЛАХ газардахын үйлдүүлэх хэв; *радиогийн утсыг газардуулах.*

ГАЗАРЗҮЙ дэлхийн гадарга, түүний адгуусан ургамал зэрэг зүйлийг судлах ухаан; **адгуусны газарзүй** (дэлхий дээр байгаа адгуусан, түүний оршин буй газар нутаг, амьдралын нөхцөл шалтгааныг судлах ухаан); **ургамлын газар зүй** (ургамлын төрөл зүйл, түүний тархалтын зүй тогтоолыг судлах ухаан); **эдийн засгийн газарзүй** (ямар нэг орны үйлдвэрийн байрлалт түүний хөгжлийн зүй тогтоолыг газарзүйн нөхцөл байдалтай холбож судлах ухаан); **газарзүйн солбицол** (уртраг өргөргийн огтлолцсон цэг); **газарзүйн зураг** (газарзүйн байдлыг зурсан зураг); **газарзүйн шинжилгээ** (газарзүйн судалгаа хийх ажил).

ГАЗАРЗҮЙЧ газарзүйн мэрэгжилтэй хүн.

ГАЗАРЛАХ 1. газарт хийх, газардах; 2. оршуулах.

ГАЗАРЛУУЛАХ 1. газардуулах; 2. хүүр оршуулах, нутаглуулах.

ГАЗАРЧ 1. газар орон, зам бай зааж өгөх хүн; *шинжилгээний ангийн газарч;* 2. газар нутгийг танин мэдэхдээ сайн хүн; *энэ их газарч хүн.*

ГАЗАРЧЛАХ бусдад зам газар заан удирдаж явах; *төөрсөн хүнд газарчлан явав.*

ГАЗАРЧЛУУЛАХ газарчлахын үйлдүүлэх хэв.

ГАЗАРШИХ орон нутагт идээших, нутагших; *говийн мал хангайд барагтайд газаршихгүй.*

ГАЗАРШУУЛАХ газаршихын үйлдүүлэх хэв.

ГАЙ I зовлонгийн уг шалтгаан; **гай зэтгэр; гай гамшиг; гай зовлон** х о р ш . ; **гай хөө** (уршиг нөлөө): **гай түй** (гай хөө); **гай татах** (өөртөө уршиг авчрах); **гай дуудах** (өөртөө уршиг даллах); **гай болох** (зовлонгийн шалтгаан болох); **гай дайрах** (санамсаргүй зовлон тохиолдох); **гайд гарах** (а. гаргуундаа хаягдах, бусдын золионд түлхэгдэх; б. гудамж худалдааны газраар явах).

ГАЙ II гудамж; *гудамж гайгаар сэлгүүцэх.*

ГАЙГҮЙ 1. аймшиг сэжиглэл бага буюу айх сэжиглэх зүйлгүй; *гайгүй аюулгүй юм; гайгүй хор багатай юм; гайгүй гайгүй;* 2. бэрхшээл төвөг бага буюу амар хялбар бүтээж болох юм; *гайгүй бэрх биш ажил; төвөг багатай гайгүй хөнгөн ажил байна;* 3. муу биш, болох зохих; *гайгүй сайн хонь авлаа; гайгүй барагтайхан юм байна.*

ГАЙЛАХ I гайд гаргах.

ГАЙЛАХ II анзаарах; *би гайлсангүй.*

ГАЙЛИГҮЙ гаалигүй, *гайлигүй оруулах зүйлийн цэс.*

ГАЙЛИЛАХ гаалилах.

ГАЙЛИЛУУЛАХ 1. гайлилахын үйлдүүлэх хэв; 2. гайлилагдах.

ГАЙЛЬ гааль; *гайлийн хороо.*

ГАЙЛЬЧ гайл хураагч хүн.

ГАЙМУУ: **гаймуу ногоо** у р г а м а л амт гашуун, язгуур ба навчийг дарж иддэг үрий нь талхалж хэрэглэдэг, гичийн төрлийн нэг зүйл ногоо, үүний үндсийг байгуэ гэнэ.

ГАЙС гай болсон юм; *гайс эд; гайс болох; гайс гаргах.*

ГАЙСЛАХ гайс болгох; *гайсалж завших.*

ГАЙТАЙ гай бүхий юм; *гайтай хэрэг болов; яасан гайтай, хөөтэй амьтан бэ чи!*

ГАЙТАХ бусдын гай уршиг халдаж нөлөөлөх, гай тусах; *ингэж гайтах гэж байх уу!*

ГАЙТУУЛАХ гайтахын үйлдүүлэх хэв; *мэргэлж эд малыг гайтуулан авсан байна.*

ГАЙХАГДАХ гайхахын үйлдэгдэх хэв; *энэ морь бол олонд гайхагдаж байгаа хурдан морь юм.*

ГАЙХАЛ 1. шогтой, зэвүүрхэлтэй юм; *чоно гайхал; гайхал хулгай;* 2. дотно бөгөөд цуутайн учир тансаглах буюу бахархаж хэлэлцэхэд хэрэглэнэ; *гайхал эрх хүүхэд; алиа хошинч гайхал;* **гайхал хонгор** (тэгмэл хонгорын өөр нэр).

ГАЙХАЛТАЙ ер бишийн гайхам юм; *гайхалтай сонин; гайхалтай сайн; гайхалтай жигтэй.*

ГАЙХАМ ер бишийн гайхмаар юм; *байгалийн байдал гайхам сайхан байв.*

ГАЙХАМШИГ онцын сайн шилдэг зүйл; *гайхамшиг зохиол; гайхамшиг сайхан эд.*

ГАЙХАМШИГТАЙ гайхаж баршгүй; *монголын соёлын өв үнэхээр гайхамшигтай их юм.*

ГАЙХАРЬ бахдаж үзмээр юм.

ГАЙХАХ 1. үйл явдлыг шийдвэрлэж үл чадан тээнэгэлзэх; *мэл гайхаж цэл хөхрөх;* 2. гайхалтай сонирхолтой юмыг шагшин сайшаах муушаах; *би энэ хүнийг үзээд их гайхав.*

ГАЙХАШ гайхах нь; *гайхаш болох; гайхаш барагдах; гайхаш тасрах.*

ГАЙХУУЛАХ 1. гайхахын үйлдүүлэх хэв; 2. гайхагдах; 3. биеэ дэмий л саймсрах, хөөрөлхөх; *чи битгий гайхуулаад бай!*

ГАЛ 1. шатаж байгаа бодисоос гарсан халуун, дөл; **гал ноцоох, гал асаах** (шатах юманд гал авалцуулах); **гал авалцах** (галын дөл шатах юманд хүрч асах); **гал алдах** (а. түймэр асахад хүрүүлэх ;б. түлшээр тасрах); **гал түлэх** (а. гал асаах; б. галд шатах юм хийж хөгжөөхөд хүрүүлэх); **гал гарах** (а. алст гал үзэгдэх; *алст гал гарч байна, айл байгаа юм байна;* б. түймэр гарах; *ойд гал гарч гэнэ);* **гал гаргах** (галыг үүдэн бий болгох; *тамхи татмаар байна, гал гаргаач);* **гал унтрах** (гал мөхөх); **гал хөгжөөх** (галыг гүнээ бадруулах); **гал улалзах** (галын холоос үзэгдэх); **гал дурвагнах** (гал хөгжин шатах); **гал дурвэлзэх** (гал хэтэрхий дурвагнах); **гал дүрэлзэх** (дурвагнах); **гал цохих** (хэт цохиж гал гаргах); **гал цогших** (галын дөл барагдах); **гал сүүмэлзэх** (галын дөл тод биш болох үзэгдэх); **галын оч** (галаас үсрэн гарсан жижиг цог); **галын нөл** (галын дөл); **галын илч** (галын халуун); **гал манах** (галын цогийг үнсээр булж унтраахгүй байлгах); **түүдэг гал** (шөнө хээр түлсэн гал); **гал хөс** х о р ш.; *гал хөсөө сэргийл!; гал хөсөө мэдэж бай!;* **гал усны гашуун зовлон** (олон зүйлийн хүнд дарлагдал); **гал цог** (ширүүн зан авиртай; *гал цог шиг хүн);* **гал тахих** х у у ч и р с а н (галд архи, тос, үнэртэн зэрэг гал хөгжөөх юм өргөх ёс); **галд тэсвэртэй** (авсаар халж, шатахгүй юм); **гал команд** (галын аюулаас сэргийлэн хамгаалах газар); **гал сөнөөгүүр** (галын аюулыг сөнөөх хэрэгсэл); **гал хамгаалагч** (цахилгаан осол аюулаас сэргийлэх хэрэгсэл); **нүдний гал** (нүдний хараа); **гал шил** (нарны гэрлийн тусгалд тохиолдуулан гал ноцоох буюу юм өсгөн томруулдаг шил); **гал цэцгий** (нүдний хар цэцгийн дундах гялбалзам гэгээнийг, хүүхэн цэцгий ч гэнэ); **гал тогоо** (а. халуун тогоо; б. хоол унд хийх газар); **гал тогооны газар** (хоол унд бэлтгэх тусгай газар); **гал улаан** (хүрц улаан өнгө); **гал голомт** (эцэг өвгийн үеэс улиран уламжилсан гэр өрөмж); **гал буриа** (бялхдас); **гал нээх** (дайсны зүг зэрэг буудах); **галын наадам** (цаасан буугаар буудах); **галын аюул** (галд автах аюул); 2. аялах зэрэгт нэг оронд хамт нийлж явах; *нэг гал аянчин;* **галын ах** (аяны нэг галын тэргүүлэгч); 3. бялт; *буугийн гал; сумын гал;* 4. Энэтхэгийн эртний гүн ухааны ёсны дөрвөн махбодийн дотоод халуун; 5. гал од (Ангараг гараг); 6. сарны зурхайн ёсны таван махбодийн хоёрдугаар; 7. бичиг сударт гурвын тоог «гал» гэсэн нь бий.

ГАЛАВ газар цогцлон тогтсон эрт цагийн амьтан, ургамал бүхий тунамал чулуулгийн нас; *цэрдийн галав; мөсөн галав;* ☆ **галав юүлэх** х у у ч и р с а н (хамаг юм үгүй болох).

ГАЛАЙХАН: **галайхан эх** бөөгийн шажны ёсонд галын эзэн.

ГАЛБИНГА а м ь т а н янз гардитай төстэй, биед таван зүйлийн өнгө бүрдсэн, эрүүний дор нэг мушгиа, цагаан чандартай нэгэн зүйл шувуу; **галбинга цэцэг** у р г а м а л (богинохон иштэй, шувуун хэлбэртэй цагаан цэцэгтэй, намар цэцэглэдэг нэгэн зүйл цэцэг).

ГАЛБИНГАЛИГ а м ь т а н урт нь гурван тохой орчим, янз тоть мэт, гардитай адил таван зүйлийн өнгө бүрдсэн нэгэн зүйл шувуу.

ГАЛБИР 1. хэлбэр, дүр; *галбир сайтай; галбир муутай;* 2. байр, үзэмж; *байр галбир; үзэмж галбир;* 3. ааш авир, төлөв байдал; *галбиргүй амьтан билээ.*

ГАЛБИРГҮЙ 1. хэлбэр дүр муутай; *галбиргүй хийцтэй эд;* 2. төлөв зэхий, ул суурь муутай; 3. ааш зан муутай; *галбиргүй хүн.*

ГАЛБИРЖИХ 1. галбираа олох; 2. төлөвжих, томоожих.

ГАЛБИРТАЙ 1. хэлбэр дүр сайтай; 2. төлөв томоотой; 3. зан ааш сайтай.

ГАЛБЫН нилээд сайн, овоо, зэгсэн; *галбын сайн.*

ГАЛГИУЛАХ галгихын үйлдүүлэх хэв.

ГАЛГИХ сонин сэвүүн байдалтай явах; *мориор галгих; замаар галгих.*

ГАЛДАХ 1. юмыг галаар шатаах; *цаас галдах; мод галдах;* 2. түймэр тавих; **галдах түймэрдэх** х о р ш.. .

ГАЛДУУЛАХ галдахын үйлдүүлэх хэв.

ГАЛЖИЙХ галжир болох; *нум галжийх.*

ГАЛЖИР I 1. муруй, хазгай; *галжир гилжир явах;* 2. юм байрнаасаа хазайх; *нумны гичир гажиж галжир болов.*

ГАЛЖИР II а м ь т а н зараатай адил төстэй, хөвчин бие нь гал улаан өнгөтэй нэгэн зүйл амьтан.

ГАЛЖИРДАХ галжрын учир тохиромжгүй болох, хэтэрхий галжир болох.

ГАЛЖИРТАХ галжир болох.

ГАЛЖРАХ галжийх, хазайх.

ГАЛЗУУ 1. ухаан мэдрэл алдаж солиорох өвчин; **галзуу хөлчүү** х о р ш.: *галзуу нохой; галзуу өвчин;* 2. ш и л ж с э н ууртай, догшин, эрчтэй, чадалтай; *унахад галзуу морь; галзуу ууртай хүн; Шилэн галзуу баатар* а м а н з о х и о л о о с.

ГАЛЗУУРАХ I галзуу солио өвчин тусч дэмийрэх, солиорох.

ГАЛЗУУРАХ II юмны эрч чадал улам өрнөж нэмэгдэх, буулих; *харцга галзуурах; бүргэд галзуурах; үзэм галзуурах.*

ГАЛЗУУРУУЛАХ галзуурахын үйлдүүлэх хэв: **үзэм галзууруулах** (үзмийг няцлан нүдэж юм нааж болохуйц болгох); 2. буулиулах; *бүргэд галзууруулах; харцга галзууруулах.*

ГАЛИГ: галиг үсэг харь хэлний үгийг тэмдэглэхэд зориулан 1587 онд Аюуш гүүш гэдэг хүний зохиосон нэг зүйл монгол үсэг, али галийн үсэг ч гэдэг; **авианы галиг** (авиаг нарийвчлан тэмдэглэхэд зориулж эрдэм шинжилгээний ажилд хэрэглэдэг нэг зүйл үсэг; галиг үсгийн бичлэг, үсгийн дүрмээс ангид бичнэ; *олон улсын галиг; нутгийн аялгууны галиг);* **үсгийн галиг** (ямар нэг бичгийн үсгийг өөр нэг бичгийн үсгээр хуулан буулгах үсэг; *уйгаржин монгол үсгийг латин галигаар буулгах).*

ГАЛИГЛАХ галиг болгох.

ГАЛИГЧЛАХ галиг үсгээр бичих.

ГАЛИРАХ халирах, хэцүүшээх, халшрах; *түүнээс галирах хэрэггүй.*

ГАЛИРХАЙ халирамхай, аймхай.

ГАЛЛАХ 1. гал түлэх буюу асаах; *пийшин галлах;* 2. галт зэвсэг буюу бууг зэрэг зэрэг ноцоох буюу буудах; *буу галлах.*

ГАЛТ гал бүхий юм; **галт зэвсэг** (галаар тэсрүүлэх зэвсэг; *галт бөмбөг; галт буу);* **галт сум** (дотроо гал цэнэгтэй сум): **галт бөмбөг** (тэсэрдэг бодисоор цэнэглэгдсэн зэвсэг); **галт тэрэг** (уур буюу цахилгааны хүчээр хөдөлж төмөр замаар явдаг тэрэг); **галт онгоц** (уурын хүчээр хөдөлдөг томхон онгоц, далай ба ихээхэн нуур, мөрөн усанд явна; *галт онгоцонд сууж явав);* **галт тогоо** (халуун тогоо); **галт уул** (газрын гүнээс гал, хумхи, бялхдасыг түрэн гаргаж, хэзээ нэгэн цагт дэлбэрч болох, оройдоо өрх бүхий уул): **сөнөсөн галт уул** (нэгэнт дэлбэрч, одоо дэлбэрэхгүй болсон галт уул); **галт уулын амсар; галт уулын өрх** (бялхдас, хумхи зэрэг зүйл гаргахад тогтсон ам); **галт уулын хумхи** (галт уул дэлбэрэхэд гарсан маш өчүүхэн бялхдасыг агаарын урсгалаар алс хол аваачсан нь); **галт уулын судлал** (дэлхийд буй галт уулын байрлалт ба дэлбэрэлт, үүсэл, дэлбэрэхэд гарсан зүйлийг судлах ухаан); **галт уулын бөмбөг** (галт уул дэлбэрэхэд гарсан бялхдас дээш хөөрөн гарч агаарт бөөрөнхий буюу бөөрөнхийвтөр хэлбэртэй болсон); **галт хорхой** а м ь т а н (цох хорхойн намын нэгэн зүйл хорхой, шөнийн цагт жирэв жирэв гэрэл гаргана).

ГАЛТАС а м ь т а н хэлбэр хулганатай төстэй бөгөөд том, 3—4 хуруу хир зузаан үстэй, улаан цагаан хоёр зүйл байдаг, шөнө гал мэт гэрэлтэй нэгэн зүйл амьтан.

ГАЛТСАН салаа мөчиргүй шулуун, урт шургааг мод

ГАЛУУ (Н) а м ь т а н усанд амьдардаг, хушуу хамшгар болоод урт, гагуйсан хүзүүтэй шувуу; зэрлэг ба тэжээмэл хоёр зүйл бий; *галуу шувууны дэгдээхэй гадаа гараад ганганаж байна* а р д ы н д у у; **галуун таваг** у р г а м а л (шарилжны төрөл, говирхог газар ургадаг; өндөр нь 20 см. орчим, ишийн бүдүүн нь дэрсний хир, навч нь шувууны таваг мэт хэлбэртэй); **галуун хүзүүт** (урт өндөр хоолойтой шил ваар зэрэг юмаар хийсэн сав).

ГАЛЧ зуух пийшинд галлах үүргийг гүйцэтгэгч хүн; *уурын зуухны галч;* **галч хулгана** а м ь т а н (бие том, жин хүнд, үс нарийн ширхэгтэй бөгөөд маш урт, өнгө цав цайм, галд маш тэсвэртэй гэдэг).

ГАМ хайрлал, хэмнэл, ариг; **хайр гам; ариг гам** х о р ш.; *эд хөрөнгийг гамтай хэрэглэж сур; дордсон биед гам хэрэгтэй; гамаа бүү алд; сайн гам хийх хэрэгтэй.*

ГАМБИР тос нүнжиггүй хайрсан бин.

ГАМГҮЙ хайрлах ариглахыг мэдэхгүй; *аршаанд ороод гамгүй байсан юм; улсын эд хөрөнгийг гамгүй зарцуулсан байна.*

ГАММ зохирол эрэмбэ.

ГАМНАХ 1. арвилж хэмнэх ба элж эвдрэхэд хүргүүжин гэж болгоомжлон хайрлан хэрэглэх; *нэгдлийн малыг гамнаж хэрэглэх хэрэгтэй;* 2. хүн биеэ энхрийлэх, арчлах; *таны нас өндөр болсон учир биеэ гамнах цаг болжээ.*

ГАМНУУЛАХ гамнахын үйлдүүлэх хэв.

ГАМС а м ь т а н хэлбэр загастай адил бөгөөд чихтэй, мэлхийн сүүл мэт сүүлтэй, гөрөөсний хөл шиг хөлтэй, арьс нь маш гилгэр, явахдаа удаан нэгэн зүйл амьтан.

ГАМТАЙ арвилах хайрлах нь сайн; *дэвтрийг гамтай хэрэглэх хэрэгтэй.*

ГАМШИГ газар оронд болсон зуд гачиг буюу үер ус, өвчин тахал мэтийн элдэв аюул; *зудын гамшиг;* **гай гамшиг; гамшиг зовлон; гамшиг тахал; аюул гамшиг** х о р ш..

ГАМШИГЛАХ гамшиг болох болгох.

ГАН I 1. цайвар өнгөтэй хатуу төмөрлөг, чанарыг өөрчлөхийн тулд нүүрс төрөгч (1,7 % хүртэл) бусад хольц төмөрлөгүүдийг хайлахад нь холино; *ган төмөр; ган болд; ган төмөр гайгүй даа галын аясыг дагана хөө* а р д ы н д у у; **ган татах** (төмөрлөг эдлэлд ган суулгах); 2. ш и л ж с э н хатуу, тэсвэртэй; *ган зоригт.*

ГАН II ан цав; **ган гав; ган цав** х о р ш.

ГАН III шингэн юм агуулах том хувин; *усны ган; гантай ус.*

ГАН IV арьс шир дүрж идээлэх тусгай найруулсан зүйл; *арьс ширийг ганд хийх.*

ГАН V. ган ган хийх *гангинах дуу чимээ; нохой ган гэж гаслав.*

ГАН VI бороо ус чухаг ховор жил, цаг; *гантай жил; ган болов;* **ган гачиг** х о р ш.: **ган болох** (ус бороо ховор болж гандах); **ган тайлах** (гандаж байгаад хур орох).

ГАНАВАЛЗАХ ганагар юмны ганас ганас хийх; *нуруу нь ганавалзаж байв.*

ГАНАГА: ганага ганага хийх ганагар юмны үргэлжлэн хөдлөх.

ГАНАГАНАХ ганагар юмны ганага ганага хөдлөх.

ГАНАГАР 1. хүн амьтны нуруу хотгор гандгар; *ганагар нуруутай хүн;* 2. гуалиг аятайхан байдалтай; *ганагар уурга; ганагар сайхан морь.*

ГАНАЙЛГАХ ганайхын үйлдүүлэх хэв, ганайхад хүргүүлэх.

ГАНАЙХ ганагар болох; *ганайж зогсов.*

ГАНАЛЗАХ ганагар юмны ганас ганас хөдлөх байдал.

ГАНАС: ганас ганас хийх ганагар юмны байн байн хөдлөх.

ГАНАСХИЙХ түр зуур ганайх.

ГАНБАГАНАХ ганбагар юмны үргэлжлэн хөдлөх байдал.

ГАНБАГАР төлөв байдал, төв аятай, намба сайтай; *ганбагар хүн; ганбагар морь.*

ГАНБАЙЛГАХ ганбайхын үйлдүүлэх хэв, ганбайхад хүргүүлэх.

ГАНБАЙХ ганбагар болох.

ГАНБАЛЗАХ ганбагар юмны байн байн хөдлөх байдал.

ГАНГА I 1. хоёр этгээдээс шахагдсан ихээхэн хавчил суваг; *гуу ганга; ганга жалга.*

ГАНГА II у р г а м а л бутан ишнээс тарж ургадаг нэг зүйл өвс, үнэр сайхан.

ГАНГАЛАХ гоёмсоглон хээнцэрлэх; *гангалах гээд маяглав.*

ГАНГАЛУУЛАХ гангалахын үйлдүүлэх хэв.

ГАНГАМСАГ хэтэрхий гоёмсог.

ГАНГАМСАГЛАХ хэтэрхий гоёмсоглох.

ГАНГАМСАГЛУУЛАХ гангамсаглахын үйлдүүлэх хэв.

ГАНГАН хээнцэр гоёмсог байдалтай; **гоё ганган** х о р ш.; *ганган хүнд гархи нэмэр з ү й р.*

ГАНГАР I 1. хамгийн нарийн сайн шаазан; *гангар шаазанд цай ууж суув;* 2. аягын хүндэтгэл.

ГАНГАР II: **гангар гунгар хийх** 1. дотночлон хүүрнэх; *аяны замд гангар гунгар гэж явав;* 2. нүүдлийн шувууны дуугарах байдал.

ГАНГАРАХ гаарах улам нэмэгдэх.

ГАНГАРХАХ ганган байдал гаргах.

ГАНГИНАХ амьтны уянгалан дуугарч гаслах; **гаслах гангинах** х о р ш.; *чи битгий гангинаад бай!, хүүхэд сэрнэ шүү; нохой гангинах чимээ сонсдов.*

ГАНГИНУУЛАХ гангинахын үйлдүүлэх хэв.

ГАНГИС доргоны өөр нэр.

ГАНДАЙХ гандгар болох.

ГАНДАЛЗАХ ганалзах.

ГАНДАН I шажны ёсны хөгжмийн зэвсэг, чөмгөн бүрээ ч гэнэ.

ГАНДАН II: **гандан гундан** гундаж гутрахад ойртсон.

ГАНДАХ 1. зуны цагт хур ховордож, ургамал хатах, ургахгүй болох; *газар дэлхий гандаж байна;* 2. намаршиж ургамлын өнгө шарлаж хувирах; *өвс ногоо гандаж эхлэв;* 3. нар салхинд юмны өнгө хувирч өгөр болох; *дээл гандах;* 4. хүний явдал хувирч гутах; *ажлаа алдаж гандаж явах хүн;* **гантах гундах** х о р ш.

ГАНДАХ II элдэж боловсруулах арьс ширийг ганд дүрж идээлэх; *арьс гандах.*

ГАНДГААРЬ у р г а м а л төрөл зүйл 20 шахам, заримыг чимэглэлд ашигладаг, мөн эмнэлэгт хэрэглэдэг бутархаг ургамал.

ГАНДГАР дундад хувь хотгорхон бөгөөд хоёр этгээд гянагар байдалтай; *гандгар нуруутай хүн; гандгар ургаа мод.*

ГАНДИРСАН: гандирсан балгасан зэргэлгээн далайгаас дэгжсэн уурын дотор хот балгас, давхарлаг гэр, оргил мэт зүйл бүрийн юмны үзэгдэх байдал дурс.

ГАНДУУЛАХ гандахын үйлдүүлэх хэв.

ГАНДЬ I шажны ёсны гэлэн санваартны хурлын урда мод.

ГАНДЬ II харагчин тотийн өөр нэр.

ГАНЖИН гурил хөвөрлөх моголцог мод, гулууз ч гэнэ.

ГАНЖИР шажны сүм барилгын орой дээрх чимэг, төмөрлөгөөр хийнэ; *загалмай ганжир.*

ГАНЗАГА эмээлийн хавтасны өмнө хойдод унжуулсан сур; *гары минь ганзаганд, хөлий минь дөрөөнд хүргэж өгөв;* **ганзага татуу** (чадвар муутай; *гар богино, ганзага татуу);* **ганзага нийлэх** (үйл ажилд сэтгэл явдал зохицож мөр нийлэх): **ганзаганы сан** х у у ч и р с а н (ан авд олз омогтой явахыг хүсч уншуулах сан); **ганзагын худалдаа** (айл өрх хэсч аар саар юм борлуулдаг наймаа).

ГАНЗАГАЛАА ганзагалсан юм; *таны ганзагалаа их хүнд байна уу?*

ГАНЗАГАЛАХ эмээлийн ганзагаар юмыг уяж торгох; *цув ганзагалах;* **толгойгоо ганзагалах** (а. доош харж гунигланн явах; б. унаан дээр үүрэглэн явах); **гуяа ганзагалах** (хоосон олз омоггүй; *гуяа ганзагалаад л ирсэн байна билээ).*

ГАНЗАЛУУЛАХ ганзагалахын үйлдүүлэх хэв.

ГАНИРАХ ганихрах, гутрах.

ГАНИРУУЛАХ ганирахын үйлдүүлэх хэв; **ганируулах унд** (хөлчүүрүүлэх унд).

ГАНИХ үйл явдалд мэрийн хичээж ажиллах; *ганьж явах; ганьж хийх.*

ГАНПАНЗ зуурсан гурил элдэх хавтгай мод; *гурилын ганпанз.*

ГАНСРАЛ гутрал, гунихрал; *гансрал гутрал; гансрал ганихрал* х о р ш.

ГАНСРАЛТ гансрал.

ГАНСРАХ үйл хэрэгт санааширч зовних, үйл явдлаас жигшин уйдаж бодлого болох; *гансарсан сэтгэл гайгүй даа, хүүгийн аясыг дагана хөө* а р д ы н д у у.

ГАНСРУУЛАХ гансрахын үйлдүүлэх хэв, гансрахад хүргүүлэх.

ГАНТАЙ 1. ган бүхий; *гантай жил;* 2. ш и л ж с э н хатуу тэсвэртэй; *гантай өвгөн шүү; гантай эр; уг нь гантайдаа одоо ийм байна.*

ГАНТАХ ган цав гарах

ГАНТИГ шохойн чулуулгаас бий болсон хувирмал чулуу; цагаан, улаан, ягаавтар мөн холимог өнгөтэй ч байдаг; гантигийг уран барилга, баримал, цахилгаан техник зэрэг зүйлд хэрэглэнэ; *бичгийн гантиг хэрэглэл; гантиг багана.*

ГАНТУУЛАХ гантахын үйлдүүлэх хэв.

ГАНХАГАНАХ ганхага ганхага хийх,

ГАНХАЛЗАХ олноор ганхах буюу байн байн ганхах; *архи уусан хүн гудамжинд ганхалзаж байв; туг далбаа салхинаа намилзан ганхалзаж харагдана.*

ГАНХАХ 1. ургаа босоо юмны найгах, нахилзах; *өвс ганхах; мод ганхах;* 2. хүн амьтны найгалзан нахилж явах ба дорой байдлаар гэлдэрхлэн явах; *ганхаж явах; ганхаж гэлдрэх;* 3. гуйвах, дайвах; *хоёрын хооронд ганхаж явах хэрэг алга.*

ГАНХВАЛЗАХ байн байн ганхах.

ГАНХУУЛАХ ганхахын үйлдүүлэх хэв.

ГАНЦ 1. бусадтай хамтраагүй, нэгээрээ, нэг, өрөөсөн; *ганц бие хүн; хүний ганц хүү; уналгын ганц морь; ганц нэг; ганц хүний суудалтай; ганц хүний ор; ганц хүн хүн болдоггүй, ганц мод гал болдоггүй* з ү й р; **ганц бөхтэй тэмээ** а м ь т а н (Африк Азийн зарим оронд байдаг тэмээ: сүү ихтэй, аян жинд хэрэглэнэ); 2. зөвхөн, онцлон тухайлсныг үгүүлэхэд хэрэглэх үг; *ганц малын ажил хийдэг; ганц хүссэн минь тэр; ганц би биш;* ☆ **ганц хуруутах** (хуруунд юм гарч идээлэн буглах).

ГАНЦААРАА хань ижил байхгүй; **ганц ганцаараа байх** (нэг нэгээрээ байх); *цор ганцаараа; гав ганцаараа.*

ГАНЦААРДАХ ганцаарын учир тохиромжгүй болох; *би энэ ажилд ганцаардаад байна.*

ГАНЦААРДУУЛАХ ганцаардахын үйлдүүлэх хэв; ганцаар болгох.

ГАНЦААРЛАХ юмыг ганцаар болгох; *азрага нэг морийг хазаж ганцаарлан хөөв.*

ГАНЦААРЛУУЛАХ ганцаарлахын үйлдүүлэх хэв.

ГАНЦАГЧИН хань холбоогүй, аминчхан, хувиа бодогч.

ГАНЦДАХ ганцын учир тохиромжтүй болох; *манай оронд мэрэгжилтэй хүн ганцдахгүй боллоо.*

ГАНЦХАН нэгхэн, нэгийн төдийхөн; *энд ганцхан мод байсан юм, одоо ургаж олон болжээ.*

ГАНШИХ I гандах төлөв байдалтай болох; *одоо бороо орохгүй бол ганших нь байна.*

ГАНШИХ II амьтны гон гон хийж муухай дуугарах; *нохой ганших.*

ГАНШИХ III үглэн янших.

ГАНЬ цор ганцааран, гань ганцааран; *гань хүн; гань бие.*

ГАНЬС I доргоны зулзага.

ГАНЬС II у р г а м а л далайн цагаан ногоо.

ГАНЬХРАЛ гансрал, санаашрал, зовнил,

ГАНЬХРАХ гунихрах, гансрах, гонсойх.

ГАР 1. хүний мөрнөөс хуруугны шувтрах үзүүр хүртэлх хэсэг; *баруун зүүн гар;* **уран гар** (урлахдаа чадамгай); **гар султай** (хүний бусдад юм хум өгөхөд их харамсдаггүй зантай); **гар сул, сул гар** (арвилах хэмнэхийг мэддэггүй үрэмхий): **гар татуу** (а. хүний бусдад өгөхдөө харамсан татгалзах зантай; б. хөрөнгө чинээгээр ядуу дорой); **хатуу гар** (а. арвилах хэмнэхдээ хэцүү буюу харамч; б. ширүүн, догшин, чанга); **гар хүнд, хүнд гартай гар хүндтэй** (а. хүний хөнгөлсөн агталсан мал нь хялбар үхэх буюу эсхүл сэхэхдээ удаан хүнд; б. гардан тарьсан нь өвчтэй, хүндий нь; в. нум дэлэхдээ хэцүү, гөрөөс зэргийг харвахад нэвтлэн даалгахдаа онц чадамгай); **гар хөнгөн, хөнгөн гартай, гар хөнгөнтэй** (а. хүний хөнгөлсөн агталсан мал нь сэхэх эдгэрэхдээ түргэний нь: б. гардан тарьсан нь өвчингүй хөнгөний нь; в. нум дэлэхдээ муу; харвахад оносон зүйлийг даалгах нь муу); **гар урт, урт гар** (а. хүний олон юманд савдан хүрэлцэхдээ чадамгай; б. хулгайч; *урт гарт; гар урттай*): **гартаа авах** (эрх мэдэлдээ оруулж эзэмших; *төрийн эрхийг гартаа авах);* **гарт орох** (а. өөрийн эрхшээлд авах; б. бусдын эрхэнд автагдах); **гар тэнийх** (харамч хүн, бусдад бага сага юм санамсаргүй өгөх): **гар дээр өсөх** бусдын хайр халамжид өсч бойжих; *эцэг эхийнхээ гар дээр өссөн хүн);* **гар дохио** гараар даллан хөдөлгөж мэдэгдэх тэмдэг); **гар бие оролцох** (өөрийн биеэр оролцох): **гар барих** (амар мэнд мэдэлцэн гар атгалцан ёс гүйцэтгэх); **гар гараасаа барилцах** (үйл ажилд хамтран зүтгэх; *энх тайвны үйлст гар гараасаа барилцан тэмцэх);* **гартаа дүйтэй** (юм юм хийхдээ чадмаг); **гар сунгах** (бусдыг хайрлан энэрч дэмжлэг үзүүлэх): **гар харах** (а. хүний үйл ажлыг үйлдэх бүтээхдээ хөлс шагнал зэргийг горилох ба өгөхийг хүлгэлзэн хүлээх; б. өөрийн хэрэглэх эд юмыг өөрийн дураар авч хэрэглэхгүй, ямагт бусдын авч өгөх ба хэрэглэхийг зөвшөөрөхийг хүлгэлзэн хүлээх); **гар нийлэх** (санаа сэтгэл, ажил явдал зохицох); **гар богино** (ядуу зүдүү; *гар богино ганзага татуу);* **гар хүрэх** бусдын биенд хал-

даж бага зэрэг жанчих; б. идээ зөвхөн амсах); **гар хөдлөх** (бусдын биед халдаж жанчилдан цуугилдах); **гар цайх** (байдгийгаа тэмтрэх, гар хосон болох); **гар цайлгах** (а. ачийн хариу бодож өчүүхэн юм талархан өгөх; б. гар хоосон болгох); **гар зангидах** (гарын хуруудыг атгаж бөөм болгох); **гар хаях** (хүний явахад хоёр гарыг урагш хойш хаялан хөдөлгөх); **гар өргөцөх** (бусдыг хүндэтгэн үзэхийн учир гараа ёслон өргөх); **гар өргөх** (а. хурал зөвлөлгөөнд хэлэлцэж тогтсон хэргийг батлахын тул гарыг дээш болгох: б. дайсанд дийлдсэнээ хүлээсэн тэмдэг болгож гараа дээш болгох); **гар үйлдвэр** (машин техникийг хэрэглэлгүйгээр гараар хийж бүтээх үйлдвэр); **гар элдүүр** (гараар элдсэн нэхий арьс; *гар элдүүрийн сур; гар элдүүрийн нэхий);* **гар уур** (тариа будаа зэргийг нүдэж талхлахын тулд бөөрөнхий модыг ухаж хийсэн сав); **гар соль** (нэг гараар барьж мод юм цавчих бага ооль); **гар онгоц** (бүхэл модыг ухаж хийсэн, цөөн хүн сууж явдаг бяцхан онгоц); **гар машин** (гараар хөдөлгөн ажиллуулах машин); **гар тээрэм** (хоёр хавтгай чулууг дүгрэг болгон засч хавсруулан тавиад гараар эргүүлэн арвай будаа зэргийг талхалдаг багаж); **гар хөрөө** (юм хөрөөдөх бяцхан хөрөө); **гар хөгжим** (гараар хөндөн хөгжимдөх хөгжмийн зэвсэг); **гар хадуур** (гарт барьж тариа өвс хадах ирт зэвсэг); **гар бөмбөг** (а. хаяж тэслэх бөмбөг, тэсрэх зүйл бүхий гараар шидэх сум, тулгарсан дайсантай тулалдахад хэрэглэнэ: б. татсан тор давуулан цохих тоглоом; нэг багт зургаан хүн байх бөгөөд хоёр баг харилцан наадна; *гар бөмбөгний баг; гар бөмбөг тоглох);* **гар урлал** (гараар урлан хийж бүтээсэн юм); **гар нийлүүлэг, гар хээлтүүлэг** (малыг гар аргаар хээлтүүлэх); **гар ажиллагаа** (машинаар биш гараар хийх ажил); **гар буу** (нэгэн гарт барьж буудаг бяцхан буу); **гар чийдэн** (зайгаар асдаг авсаархан чийдэн); **гар хөл болох** (ямар нэгэн үйл явдалд нөгөө хүний даалгаврыг гүйцэтгэж явах); **гар бариад бугуй барих** (цаашид даврах, ахиж дөхөх); **гараа гаргах** (байгаа чадлаа гаргаж мэрийн бүтээх; *гараа гаргаж оёх; гараа гаргаж зурах);* **гараа үүрэх** (нуруугаа үүрэх); **гараа тэврэх** (элгээ тэврэх); **гараас гарах** (а. хийж байгаа юмаа бүрмөсөн дуусах; *энэ өдөр нэг хос гутал гараас гарав;* б. өсч бойжиж биеэ даах буюу ажиллагаа бага орох болох; *манай хүү гараас гарч байна;* в. хэрэгцээгүй болох; *миний гутал урагдаж гараас бүрмөсөн гарав);* **гарын үсэг** (албан амины бичиг баримтад баталж зурсан нэр); **гарын бэл** (ойр зуур бага сага юманд хэрэглэх зүйл; гарын зарлага); **гарын дор** (а. бусдын эрхшээл дор: б. бэлэн байгаа; *гарын дор байгаа материалаас үзэхэд ..*); **гарын юм** (нарийн ховор хайртай юм); **гарын бээлий** (гарт өмсөх углаа хувцас); **гарын үзүүрээр хийх** (амар хялбар хийх); **их гарын** (заль мэхтэй): **дунд гарын браунинг** (дунд зэргийн хэмжээтэй браунинг буу); **баруун гарын хүн, гарын нөхөр** (дотнын сайн нөхөр); 2. юмны хоёр этгээдийг заахад хэрэглэнэ; *үүний зүүн гарт; замынхаа баруун гарыг барьж яваарай;* 3. багаж хэрэглэлийн бариул; *көрөөний гар; дугуйн гар;* 4. хуучирсан хоёрын тооны ёгт нэр; 5. Лхагва гараг; *гар гараг.*

ГАРАА 1. амьтны гарсан даруйн үйл ажлын явц; *гараа сайтай морь; гараа муутай;* шатрын гараа; 2. гарцаа, оноо; би *өөрийн гараа дээр барилдана; гараагаа хүлээж байна*

ГАРААШ машин тэрэг агуулах засварлах газар; *хөнгөн тэрэгний гарааш; гараашийн дарга.*

ГАРАГ I 1. долоо хоногийн өдрийг ээлжлэн эзлэх нэр; *Даваа гараг ажилдаа очно;* 2. нарны аймгийн ертөнцсийн нэр; *гараг хоорондын автомат станц.*

ГАРАГ II: **гараг өвчин** биений мөч эрхтний мэдрэл алдагдах өвчин; **гараг саа** хорш..

ГАРАЖ гарааш.

ГАРАЛ юмны уг үүсгэл; *хүний гарал;* **үгийн гарал судлал** (ямар нэгэн үг хэрхэн яаж үүсч, хувиран өөрчлөгдсөнийг судлах ухаан); **үгийн гарал судлалын толь бичиг** (үгсийн гарлыг тодорхойлон шинжилж хийсэн тусгай толь бичиг): **гарал үүсэл** хорш..

ГАРАЛТ 1. үйлдвэрээс үйлдэн гаргаж байгаа зүйл; **үйлдвэрийн гаралт;** 2. ямар нэгэн юмнаас шинээр бий болсон зүйл; **тарианы гаралт; сүүний гаралт.**

ГАРАМ I 1. мөрөн голын усыг уналга хөлөөр туулах олом буюу онгоц хөлөг тавьж гарах тавилан газар; **олом гарам** хорш.; 2. замын огтлон зорчиж болох гарц; *гармын дохио; гармын манаач.*

ГАРАМ II урт түрийтэй гутал.

ГАРАМГАЙ юмны бусдаас онц давуу чанар; *гарамгай эрдэмтэн; гарамгай баатар; гарамгай эмч; гарамгай хурдан; гарамгай зураач; гарамгай сүүтэй үнээ.*

ГАРАН: гаран орон, орон гаран 1. суурь гогцвор муутай; *орон гаран байж энэ өдрийг өнгөрөөв;* 2. гаруй; *хорь гаран; зуу гаран.*

ГАРАНГА I үнэг зэрэг жижиг амьтныг гөрөөлөх зэвсэг; *гаранга тавих.*

ГАРАНГА II 1. бага насны адууны эрүүний арааны өмнөд үзүүрт ургах бяцхан шүдний нэр, аранга ч гэнэ; 2. гүен, морь луусын хамрын нүхний гадаад ирмэгт мөгөөрс ургах өвчин.

ГАРАНҒА III аранга; *хувцсандаа гарангатай хүүхэд.*

ГАРАНГАТАХ 1. бага насны адуунд гаранга шүд ургах; 2. морь луусын хамрын нүхний гадаад ирмэгт мөгөөрс ургах, үүнийг гүентэх ч гэнэ.

ГАРАХ 1. юмны буй болох, үүсэх, эхлэх, далд байсан юм ил болох; **нар гарах** (а. нар мандаж эхлэх; *зүүн зүгээс нар гарлаа;* б. хүсч мөрөөдсөн зүйл нь сэтгэлчлэн бүтэх буюу баяр хөөр болох; *хүү чинь ирж нар чинь гарч байна уу?);* **сар гарах** (а. сар мандан үзэгдэх; *сар гарч оторгуйг гийгүүлэв;* б. сар эхлэх; *нэгдүгээр сар шувтарч хоёрдугаар сар гарах);* **хээл гарах** (а. гэдэс гарах, цадах; б. мал өвс ногоонд сайн цадаж тэвээрэх байдал орох); **гал гарах** (а. түймэр асах; б. шөнийн цагт хол газар гал үзэгдэх); **ус гарах** (а. юмнаас ус нэвчих, ундрах: б. ус гаталж нэвтрэх); **уур гарах** (а. хилэн намжиж дарагдах; б. тогоо нэрэхэд жалавчны дотоодоос уур хөөрөн үзэгдэх; *уур гарч байна, ус баахан бий);* **хөлс гарах** (а. биеэс хөлс дааварлах; б. ажил хөдөлмөрт хүч гаргах); **сорви гарах** (а. яр шархны ул ором үлдэж тогтох: б. үйл ажлын ямар нэгэн сэдэв цухуйж илрэх); **баас гарах** (а. машид айх; б. машид чармайх: в. үйл ажлын муу дутагдал илрэх); **гадаа гарах** (гэр хашаа зэргээс гадагш гарах); **ногоо гарах, газар гарах** (ургамал ургаж дэлгэрэх); **нүд гарах** (цас хайлж газар цоохордох); **шүд гарах** (амьтны шүд анх ургаж цухуйх); **шөл гарах** (махны шүлт шим нь усанд буух); **цагаан мах гарах** (хошгиног урваж гадагш гарах); **нэр гарах** (алдарших); **дуу гарах** (дуугарах): **чимээ гарах** (а. чимээ мэдэгдэх; б. сураг мэдэгдэх); **концерт гарах** (концерт тоглох): **кино гарах** (кино үзүүлэх); **жүжиг гарах** (жүжиг тоглох); **гэдэс гарах** (их л цадах); **хоног гарах** (цагаан идээ элбэгших); **яр гарах** (яр бий болох); **үүл гарах** (үүл бий болох); **хүүхэд гарах** (төрөх): **гарз гарах** (гарз учрах); **гай гарах** (гай тохиолдох); **алдагдал гарах** (алдагдал учрах): **алдаа гарах** (осолдох, эндэх); **ашиг гарах** (ашиг орох); **цээр гарах** (цээр арилах); **тайлан гарах** (тайлан учир бүрдэх): **орон гарах** (орон тоо бий болох); **идэш гарах** (идэх юм бий болох); **хэл ам гарах** (хэл ам хэрүүл шуугиан үүсэх); **үнэр гарах** (үнэр сэрэгдэх); **цус гарах** (цус гоожих); **зам гарах** (а. зам бий болох; б. зам хөндлөн огтлох); **улай гарах** (амьтны шинэ сэг бий болох); **мөр гарах** (а. журам бий болох; б. юмны ор мөр үлдэх); **хэрэг гарах** хэрэг үүсэх, дэгдэх); **байлдаан гарах** (дайн үүсэх); **жил гарах** (жил эхлэх); **ярьж гарах** (ярьж эхлэх); **бичиж гарах** (бичиж эхлэх); **идэж гарах** (а. идэж эхлэх; б. ихэд идэх); **буханд гарах** (үнээ хээл олох); **нөхөрт гарах** (нөхөрт очих); 2. дотор байсан юм гадагш болох, зайлах, шилжих, саяж ангижрах; **хотоос гарах** (хотоос гадагш явах); **нутгаас гарах** (нутгаасаа гадагш явах): **хөдөө гарах** суурин газраас гадагш явах); **эмнэлгээс гарах** (эмнэлгээс ангижрах): **ялаас гарах** (ялаас мултрах); **ажлаас гарах** (ажлаас халагдах); **хэргээс гарах** (а. ял хэргээс салах; б. ямар нэг юм хэрэглэх аргагүй :болох); **хоолноос гарах** (хоол идэж чадахгүй, дургүй болох); **тамхинаас гарах** (тамхи татахгүй болох); **махнаас гарах** (мах идэхгүй болох); **будаг нь гарах** (а. будаг нь арилах; б. будаг нь илрэх); **архи гарах** (а. согтоо нь гарах; б. архины чанар сайн байх); **амин гарах** (а. амьтны үхэж амьсгалаа хураах; б. аюул хөнөөлд үхэхгүй амьд үлдэх); 3. гатлах, гэтлэх, туулах, нэвтрэх, алгасаж өнгөрөх; *гол гарах; гүүрээр гарах; замаар гарах; усаар гарах; хашаа тойрч гарах, байшингийн хажуугаар гарах; гэрийн урдуур гарах; уулан дээгүүр гарах; хил гарах; хязгаар гарах;* 4. юманд авирах, асах, хүрэх, явах, багтах, *модонд гарах; ууланд гарах; шат өөд гарах; байшин дээр гарах; анд гарах; кинод гарах; сонинд гарах;* **толгой дээр гарах** (эрхшээл нь хэтрэх); ☆ **гарахын тийн ялгал** (монгол хэлний долоон тийн ялгалын нэг); **гарахын орон** (гарахын тийн ялгал).

ГАРВАЛЬ анхны үүдэл; *хүн төрөлхтний гарваль.*

ГАРГАГДАХ 1. гаргахын үйлдэгдэх хэв; 2. гаргаж болох; *гаргагдах бичиг байна.*

ГАРГАГДАХГҮЙ гаргаж уншиж болохгүй.

ГАРГАЛ журам зүйг гаргаж зөв бурууг сэнхрүүлэн тайлбарласан бичиг зохиол.

ГАРГАЛГА бичиг зохиолын санаа зорилт, утга агуулгыг тодорхойлон гаргаж бичгийн сүүлд хавсаргасан нь

ГАРГАХ гарахын үйлдүүлэх хэв; гарахад хүргүүлэх; **муу зан гаргах** (муухай аашлах);

их зан гаргах (тоомсоргүй байдал үзүүлэх); **гомдол гаргах** (гомдсоноо мэдэгдэх); **өргөдөл гаргах;** (өргөдөл өгөх); **үг хэл гаргах** (өгүүлэл тавих) чимээ гаргах (а. дуу авиа үүдүүлэх, б. сураг мэдэгдэх); **мэдээ гаргах** (ямар нэг юмны тухай дэлгэрэнгүй буюу товч мэдээлэх); **тогтоол гаргах** (хэлэлцэн шийдсэнээ бичиж албан ёсоор батлах); **шийдвэр гаргах** (шийдэх); **санал гаргах** (санасан бодсоноо хэлэх); **ажлаас гаргах** (ажлаас халах, чөлөөлөх); **гадаадад гаргах** (хил давуулан гадаадад явуулах); **бүтээгдэхүүн гаргах** (боловсруулан бэлэн болгох); **баатар зориг гаргах** (үнэхээр зориг баатарлагаа үзүүлэх); **идэвх гаргах** (юманд мэрийлт санаачлага тавих); **зээллэг гаргах** (тодорхой болзолтойгоор мөнгө зээлэн авах санхүүгийн нэг ёс); **ном гаргах** (ном зохиол хэвлэн нийтлэх); **дүн гаргах** (дүгнэж зүйл дуусгах) **хэвлэн гаргах** (хэвлэж зүйл дуусгах); **баримт гаргах** (бичиг баримт бичиж өгөх): **батлагаа гаргах** (юмыг нотлон бичиж өгөх); **гараас гаргах** (бүрмөсөн дуусгах); **гаргуунд нь гаргах** (чөлөөтэй болгох): **хүүхэд гаргах** (амаржих, нярайлах, төрөх); **хээ гаргах** (хээлэх); **хонь гаргах** (хонь нядлах, алах): **идэш гаргах** (өвөл хаврын улиралд хэрэглэх махаа бэлтгэх); **хоол гаргах** (а. боловсруулсан хоолны зүйлийг савнаас нь гаргах; б. идшинд мал алах); **бичиг гаргах** (а. гадагш нь бичиг явуулах; б. бичиг үсэг мэдэх).

ГАРГУУ I бусдаас давуу, онцгой.

ГАРГУУ II яллан авах эд юм

ГАРГУУД бусдаас давуу, онцгой, тасархай.

ГАРГУУДАА 1. гаргууд; 2. хэрэгцээгүй, дэмий; *эвдэрч гаргуудаа гарсан юм;* 3. гарзандаа

ГАРГУУЛАХ 1. гарахын үйлдүүлэх хэв; 2. гаргагдах.

ГАРГУУР юмыг гадагш зайлуулах хэрэглэл, гаргуул ч гэдэг; *хогийн гаргуур.*

ГАРДАХ юмыг өөрийн гар биеэр эрхлэн гүйцэтгэх; *гардаж өгөх; гардаж хийх;* **гардан байлдаан** (хүйтэн зэвсэг, нудрагаар жанчилдан байлдах байлдаан).

ГАРДИ үлгэр домогт гардаг асар том шувуу; *хан гарди; жигүүртний хаан гарди, араатны хаан арслан.*

ГАРДУУЛАХ гардахын үйлдүүлэх хэв, гарт нь хүргэх; *одон гардуулах; итгэмжлэх жуух бичиг гардуулах.*

ГАРЖ: гарж нохой бие бүдүүн, үс сахлаг толгой **том,** дуу өтгөн, нэгэн үүлдрийн нохой.

ГАРЗ I. орз гэдгийн эсрэг утга; эд хөрөнгөнд учирсан хохирол сүйтгэл; **гарз хохирол; гарз сүйтгэл; гай гарз** х о р ш.: 2. үйл, үйлдвэрийн үр бүтээлгүй ажиллагаа; *биеийн гарз; хөдөлмөрийн гарз; гарын гарз.*

ГАРЗАЙХ гарзгар болох.

ГАРЗГАР хүн амьтны туранхи дорой, юмны эе эвгүй хэрзгэр.

ГАРЗДАХ гарз болох; *хэлээд хэлээд хэл гарздахын нэмэр.*

ГАРЗДУУЛАХ гарздахын үйлдүүлэх хэв; *гарз болгох.*

ГАРИГ гараг.

ГАРЛАГА 1. уг үүдэл, гарал; 2. гарз; **гарз гарлага** х о р ш.; 3. зарлага; *орлогоос гарлага нь их байв.*

ГАРЛАХ 1. өөрийн гараар гүйцээх; 2. гараар хийх; 3. гар болох.

ГАРНИЗОН хот, цайз, бэхлэлт бүхий газар оршин байгаа цэргийн анги; *Улаанбаатар хотын гарнизон.*

ГАРТААМ хагас эрдэнийн чулуу; хатуугийн зэрэг 7. гартаамыг жижиг сажиг зүйл, цагны чулуу хийхэд хэрэглэнэ.

ГАРТАХ тэмцэлдэх үйл явдалд бусдад автагдах дийлдэх; *би сэц булаалдаад гартав.*

ГАРУЙ барагцаалсан илүүдэл хэмжээ; *арав гаруй; хорь гаруй; метр гаруй; кило гаруй.*

ГАРХИ төмөрлөгийн зүйлээр цагариг адил матриулан хийсэн зүйл; хазаарын гархи; хурууны гархи; **гархин хуяг** (өчүүхэн гархинуудыг холбож хийсэн хуяг).

ГАРХИДАХ гархиар торгож тогтоох.

ГАРХИДУУЛАХ гархидахын үйлдүүлэх хэв.

ГАРХИЛАХ гархи мэт болох; *нүд гархилах.*

ГАРХИТАХ гархилах.

ГАРХИТУУЛАХ гархитахын үйлдүүлэх хэв.

ГАРЦ I гарах хэмжээ; *сүүний гарц; ноосны гарц; газрын гарц.*

ГАРЦ II гарах газар, гарам, олом; *усны гарц.*

ГАРЦААГҮЙ зайлшгүй, лав, лавтайяа; *өнөөдөр ч гарцаагүй ирэх болсон.*

ГАРЧИГ ном хэвлэл бичиг зохиолын дотор багтаж орсон зүйлийн хураангуй товъёг; *энэ номын гарчиг нь хаа байна.*

ГАРЧИГЛАГЧ гарчиг үйлддэг хүн.

ГАРЧИГЛАХ 1. ном зохиолын дотор багтаж орсон зүйлд хураангуй товъёг хийх; 2. ном зохиолд бүртгэл данс үйлдэх; 3. ном сонины гарчиг төдийхнийг харж өнгөрөх.

ГАРЧИГЛУУЛАХ гарчиглахын үйлдүүлэх хэв.

ГАРШ 1. орш гэдгийн эсрэг утга; гадагш гарсан юм; 2. гарз, хохирол.

ГАРШИХ 1. бусдын үйлчлэлд дадаж идээших, үйл ажилд дадаж эрхших.

ГАРШУУЛАХ гаршихын үйлдүүлэх хэв.

ГАСАЛГАХ гаслахын үйлдүүлэх хэв, бусдыг зовоох.

ГАСАН насандаа тэнгүй сэрэглэн хүүхэд; *гасан хүүхэд.*

ГАСЛАН хүн амьтанд зовох гомдох хэрэг үйл тохиож шаналсан сэтгэлийн зовлон.

ГАСЛАХ 1. зовлонтой гомдолтой хэрэг үйл тохиож энэлэн зовох; 2. нохойн жанчигдаж ган ган дуугарах; *нохой гаслах.*

ГАСЛУУЛАХ гаслахын үйлдүүлэх хэв.

ГАСХА зэрлэг төмс, сонгино, мөөг зэргийг ухахад хэрэглэх модон хэрэгсэл.

ГАТАЛГА гаталж болох газар, гарам, тавилан; *голын гаталга.*

ГАТАЛГАГЧ гаталгадаг хүн.

ГАТЛАХ юмыг туулан давах, гэтлэх; *ус гатлах; говь цөлийг гатлах; хүнд бэрхийг гатлах.*

ГАТЛУУЛАХ гатлахын үйлдүүлэх хэв.

ГАХАЙ 1. том биетэй, богинохон хөлтэй, ац туурайт, сүүн тэжээлтэн амьтан; зэрлэг тэжээвэр хоёр зүйл байдаг; гахайг мах, өөх, үсийг ашиглахын тулд тэжээдэг; 2. сарны зурхайн ёсны 12 эрхтний 12-р; *гахай жил;* **гахай сар** (билгийн улирлын өвлийн тэргүүн сар): *гахай өдөр;* **гахай цаг** (шөнийн 21—23 цагийг дуустлах); 3. ш и л ж с э н **гахай шиг амьтан** (ховдог идэмхий хүн); **гахай хавдар** (бахуу гэдэг хоолойн өвчин); **гахай эм** у р г а м а л (иш нарийн, салаа үлэмж, хөх навчтай); **гахай харцагай** а м ь т а н (хушуу улаан, хоолойн доод этгээд цагаан нэг зүйл бялзуухай); **гахайн сор** (гахайн ширүүн шулуун урт үс); **гахайн сур** (гахайн арьс).

ГАХАЙЛИГ гахайс.

ГАХАЙС зэрлэг гахай.

ГАХАЙЧ 1. гахай маллагч; 2. гахай агнадаг.

ГАХАЙЧЛАХ 1. гахай агнах; 2. хүний тэнэг мулгуу байдал гаргах.

ГАХАЙЧЛУУЛАХ гахайчлахын үйлдүүлэх хэв.

ГАЦАА I саад, садаа, боомт, хясал; *над гацаа тохиолдов; гацаатай хэрэг.*

ГАЦАА II явах зорчих замд нэгэн этгээдээс ус, нөгөө этгээдээс хад хясаа боосон бэрх газар.

ГАЦАА III хот балгасны гадна хүй хүйгээр оршсон айл; **гацаа хүй; гацаа тосгон** х о р ш..

ГАЦАА IV хэрсгэлэн босгосон шөргөн хайс.

ГАЦААЛАХ I гацаа хайс босгох.

ГАЦААЛАХ II гол мөрний хөлдөх; *ус гацаалах.*

ГАЦААХ гацахын үйлдүүлэх хэв.

ГАЦАГДАХ гацахын үйлдэгдэх хэв.

ГАЦАР цонхны гулд мод.

ГАЦАХ 1. ямар нэгэн юманд саад тасалдал бий болох; *хяхах гацах;* 2. буугийн гал авалцахгүй буюу сум нь тээглэх, тасалдах; *буу гацах; пулемёт гацах;* 3. юмны авцалдан хөлдөх; *ус гацах; гацаж хөлдөх.*

ГАЦСАН: гацсан загас мөсөнд хавчигдаж хөлдсөн загас.

ГАЦУУ 1. ядуу дутуу, **ядуу гацуу; дутуу гацуу** х о р ш.; 2. бачуу давч; *хугацаа даан ч гацуу.*

ГАЦУУЛАХ 1. гацахын үйлдүүлэх хэв; 2. гацагдах.

ГАЦУУР аливаа модны нарийн салаа мөчир; *модны мөчир гацуур.*

ГАЧААЛ ган зудтай буюу өлсгөлөн ,ховор, хатуу бэрх цаг; *цагийн гачаал; өлсгөлөн гачаал; гачаал цаг.*

ГАЧИГ гачаал; *зуд гачиг; ган гачиг; гачиг тохиолдох.*

ГАЧИГДАЛ боогдол, дутагдал, мөхөсдөл; *над гачигдал тохиолдов; ар гэрийн гачигдлаар явав.*

ГАЧИГДАХ хүний элдэв эд хэрэглэхүүнээр мөхөсдөн дутагдах ба зовлон зүдгүүрт мохох; *эдүгээ гачигдах дутагдах юмгүй сайн сайхан амьдарч байна.*

ГАЧИГДУУЛАХ гачигдахын үйлдүүлэх хэв; *түлээ нүүрсээр гачигдуулах.*

ГАЧУУР у р г а м а л нарсны намын шилмүүст мод, мөнх ногоон шилмүүстэй, сүлд наадамд хэрэглэнэ, сүлд мод ч гэдэг.

ГАШИЛГАХ гашлахад хүргүүлэх; *сүү гашилгах.*

ГАШЛААХ гашилгах.

ГАШЛАХ ямар нэг юмны чанар хувирч ялзран муудах; *сүү гашлах; хоол гашлах.*

ГАШЛУУЛАХ гашлахын үйлдүүлэх хэв.

ГАШУУ: уй гашуу эмгэнэл, энэлэл.

ГАШУУДАЛ үхэл, хагацал, өвчин зэрэг энэлэх, зовох үйл явдал тохиолдсоноос учирсан харамсал; **гашуудал зарлах** (гашуудах хугацааг тогтоон мэдэгдэх); **гашуудлын цуваа** (гашуудан яваа хүмүүс ёс журмаар жагсан яваа); **гашуудлын хөгжим** (гашуудан бий үед хөгжимдөх уйтгарт хөгжмийн ая).

ГАШУУДАХ 1. тохиолдсон энэлэх зовох үйл явдалд харамсах, гаслах; 2. юмны гашуун амт хэтдэж зохисгүй болох.

ГАШУУДУУЛАХ гашуудахын үйлдүүлэх хэв.

ГАШУУН 1. хэлний сэрэгдэхүүнд үл тааламжлагдах хатан нясуун амт; *гашуун ус; гашуун амтагдах;* 2. энэлэл, зовол, уйтгарлал; *гашуун зовлон; гашуун бэрх; гал усны гашуун зовлон;* **гашуун утаа** (нүд арган хорсмоор утаа); **гашуун нясуун** (эвгүй муухай амт): **гашуун нясуун; гашуун хухуун** х о р ш.; **гашуун үг** (бусдын дургүй буюу зэвүү хүрэм ёжтой дэгээтэй үг).

ГВАРДИ 1. торгон цэрэг; 2. тэргүүний шилдэг цэрэг; *гвардийн тэмдэг; гвардийн хороо.*

ГЕКТАР 10000 хавтгай дөрвөлжин метртэй тэнцэх талбайн хэмжээ; га; *нэг гектараас 25 центнер тариа авав.*

ГЕНЕРАЛ цэргийн дээд тушаалын цол; *хошууч генерал; дэслэгч генерал; хурандаа генерал; армийн генерал.*

ГЕНЕРАТОР үүсгүүр.

ГЕОГРАФИ газарзүй.

ГЕОЛОГИ газар судлал.

ГЕОЛОГИЧ газар судлалч

ГЕОМЕТР хэмжих ухаан; *геометрийн томьёо.*

ГИ: ги буга а м ь т а н бие бяцхан ардуу гөрөөсөнд адил, хүдэр мэт хөлтэй, эвэр гурын эвэр адил, нэг зүйл гөрөөс.

ГИВААН шар өнгөтэй шороо, чулуу; шороо чулуу хоёр зүйл байдаг, хаяа үхэр, зааны гэдэснээс гардаг, эмнэлэгт хэрэглэнэ; *хүнд нэг ухаан, үхэрт нэг гиваан* з ү й р.

ГИВЛҮҮР эмэгтэйчүүдийн нүүр халхлах хувцас; нимгэн торгомсгоор хуниас гарган, хоёр хажууд нь оосор хадаж хийнэ.

ГИВНҮҮЛЭХ гивнэхийн үйлдүүлэх хэв.

ГИВНҮҮР гиенүүр.

ГИВНЭХ гиенэх.

ГИЕНҮҮЛЭХ гиенэхийн үйлдүүлэх хэв.

ГИЕНҮҮР гиенэхдээ баахан дуртай.

ГИЕНЭХ огцом муухай дуугарах.

ГИЖИГ 1. хүн амьтны суга хоолой зэрэг газар юм хүрэхэд сочиж зэвүүрхэн тэсч ядмаар болдог нь; *суганы гижиг; гижиг хүрч байна;* 2. эмзэг, хөндүүр, эгзэг.

ГИЖИГДҮҮЛЭХ 1. гижигдэхийн үйлдүүлэх хэв; 2. гижигдэгдэх.

ГИЖИГДЭХ 1. гижгий нь хүргэх; 2. эгзэгтэй газрыг гаргаж дургүйгий нь хүргэх.

ГИЖИГЛЭХ хүн амьтны гижигтэй газрыг чичлэх нухлах зэргээр тэсч ядуулах.

ГИЖИГТЭЙ гижиг ихтэй.

ГИЙГҮҮЛЭГЧ 1. уушигнаас гарсан хий амны хөндийд ямар нэг саад бэрхшээлтэй тохиолдож бий болсон авиа; *хамжих гийгүүлэгч; чанга гийгүүлэгч; зөөлөн гийгүүлэгч;* 2. мөн авиаг тэмдэглэсэн үсэг; *монгол үсгийн цагаан толгой 20 гийгүүлэгч үсэгтэй.*

ГИЙГҮҮЛЭХ 1. гийхийн үйлдүүлэх хэв; 2. гэрэл гэгээтэй болгох, гэгээрүүлэх; 3. чамлан шоодох санаа; *хадмынх чинь чамайг юугаар гийгүүлэв дээ!*

ГИЙГЭНЦЭР гоорхог хээнцэр; *хүнд хоосон гийгэнцэр зан хэрэг байдаггүй.*

ГИЙГЭНЦЭРЛЭХ хүний гоорхон, оморхон маяглан явах.

ГИЙГЭХ 1. гэгээтэй болох; 2. базаахгүй гэж чамлах санаа; *гийгэх ч юм алга байна; яваад гийгэх үгүй дээ, тэр ч.*

ГИЙЛГЭХ гийхийн үйлдүүлэх хэв, гийхэд хүргүүлэх.

ГИЙСГЭХ хөрөнгө юмыг албаар талах, цөлмөх; *хөрөнгий нь гийсгэх;* хийсгэх ч гэдэг.

ГИЙСЭМ маш цавчим өндөр хад; *гийсэм хадан дээгүүр явахад толгой эргэж байв.*

ГИЙХ 1. гэгээтэй болох; *үүр гийх; тэнгэр гийх;* 2. шилжсэн баяр хөөр болох; 3. төрөхийн хүндэтгэл.

ГИЙЧИН зочин, айлчин, гаднаас ирсэн хүндэтгэвэл зохих хүн; **гийчин зочин; айлчин гийчин** хорш.; *манайд гийчин ирнэ .*

ГИЙЧИРХҮҮЛЭХ гийчирхэхийн үйлдүүлэх хэв.

ГИЙЧИРХЭХ гийчний маяг байдал гаргах.

ГИЙЧЛҮҮЛЭХ гийчлэхийн үйлдүүлэх хэв.

ГИЙЧЛЭХ 1. гийчин хүнийг хүндэтгэн зочлох ба гийчин болж явах; 2. гачиг ховор цагт малыг энд тэнд эрэн бэлчээрлүүлэн идэшлүүлэх; *гийчилж бэлчээрлүүлэх; бэлчээрийг гийчилж ашиглах.*

ГИЛБЭГНЭХ 1. юмны өнгө зүсэм гэрэлтэж үзэгдэх; 2. айн ширвээтэх, бэмбэгнэх; 3. юмны гилбэг гилбэг хөдлөх.

ГИЛБЭЛГЭЭН алсад цахилж байгаа цахилгаан; *алсад гилбэлгээн жалбалзаж байв.*

ГИЛБЭЛЗҮҮР ургамал өндөр иштэй, навч нь ногоон, зун цэцэглэдэг нэгэн зүйл цэцэг.

ГИЛБЭЛЗЭЛ: гилбэлзэл цэцэг ургамал алга дарам том, гилбэгнэм улбар шар өнгөтэй цэцэг.

ГИЛБЭЛЗЭХ 1. гилбэгнэх; 2. юмны гилбэс гилбэс хөдлөх.

ГИЛБЭР харвуулын сумны үзүүрт хатгах төмрөөр хийсэн өргөн зэв; *сумны гилбэр.*

ГИЛГЭНҮҮЛЭХ гилгэнэхийн үйлдүүлэх хэв.

ГИЛГЭНЭХ гилгэр юмны гилэг гилэг хийх.

ГИЛГЭР 1. өө сэвгүй, гөлгөр мөлгөр; *гилгэр толгой;* 2. гулгариа, ширүүн биш юм.

ГИЛГЭРЭМ өнгө зүс жавхлантай сайхан юм; *гилгэрэм сайхан өнгөтэй; гилгэрэм аятайхан зүстэй.*

ГИЛГЭРЭХ юмны өнгө зүс гилбэгнэм хээ сайхан үзэгдэх.

ГИЛЖГИЙ 1. хүн амьтны хүзүү нь хазгай; *гилжгий хүзүүтэй;* 2. муруй хазгай; *багана нь гилжгий болжээ.*

ГИЛЖГЭНЭХ гилжгэр юмны гилжгэ гилжгэ хийх; *толгой нь гилжгэнэж байна.*

ГИЛЖИЙЛГЭХ гилжийхийн үйлдүүлэх хэв.

ГИЛЖИЙХ гилжгий болох.

ГИЛЖИЛЗЭХ гилжгэр юмны гилжис гилжис хийх.

ГИЛЖИР гилжгий хүзүүтэй.

ГИЛЖИРГЭНЭ амьтан богширгын төрлийн нэг зүйл шувуу.

ГИЛЖИСХИЙХ түр гилжийх.

ГИЛИЙЛГЭХ гилгэр болгох.

ГИЛИЙХ гилгэр болох.

ГИЛТЭГНЭХ юмны өнгө зүс тос даасан мэт аятай сайхан үзэгдэх.

ГИЛЭЛЗЭХ гилгэр юмны гилс гилс хийх.

ГИЛЭХ малыг шаардан тууж явуулах; *мал гилэх; үхэр гилэх.*

ГИМНАСТИК бие махбодийг чийрэгжүүлэн хөгжүүлэх бүх төрлийн дасгалууд; *гимнастик хийх.*

ГИН I төрийн ятга; **гин чиан ги амьтан** (янз гургуултай адил, өрөвлөгтөө тогосын адил ногоон нудтэй нэг зүйл шувуу): **гин ги амьтан** (гургуултай адил болоод жижигхэн, өд өрөвлөг таван зүйлийн сайхан өнгөтэй нэгэн зүйл шувуу); **гин цэцэг** ургамал (мод цэцэг, лис цэцгийн адил, цэцгийн өнгө улаан, улаавтар, хүрээ цагаан янз янз, өглөө цэцэглэж үдэш зулгардаг, навч ялам модны навчтай адил бөгөөд араатай нэгэн зүйл цэцэг).

ГИН: II **гин дүү** тариа хэмнэх сав, янз дүүтэй адил, нэг дүү найман шин багтана.

ГИНГИЙН: гингийн цаас нимгэн болоод бат нэгэн зүйл цаас.

ГИНГЭНҮҮЛЭХ гингэнэхийн үйлдүүлэх хэв.

ГИНГЭНЭХ нарийн дуугаар уянгалан дуугарах; *гингэнэн унших; гингэнэн уйлах; гингэнэж улих; гингэнэн дуулах.*

ГИНЖ 1. нэгийг нөгөөд нь оруулан хэлхсэн төмөр оосор; *нохойн гинж; өргөх гинж;* 2. шилжсэн уяа оосор; **боолын гинж тасрав** (боолчууд тэмцэлд босов).

ГИНЖЛҮҮЛЭХ 1. гинжлэхийн үйлдүүлэх хэв; 2. гинжлэгдэх.

ГИНЖЛЭГДЭХ гинжлэхийн үйлдэгдэх хэв.

ГИНЖЛЭХ юмыг гинжээр торгож уях; *зуудаг нохойг гинжлэн уяв.*

ГИНШИГНЭХ байн байн гинших.

ГИНШИХ I гингэнэх; *нойр хурч байна чи, би гий гиншээд бай!*

ГИНШИХ II бөө нарын үглэж залбирал үйлдэх.

ГИНШҮҮЛЭХ гиншихийн үйлдүүлэх **хэв.**

ГИРДЭГ з у р х а й сарны зурхайн 28 одны нэг.

ГИРЭВ саная мэдрэл бядуу дорой; *гирэв хүн.*

ГИРЭВШИХ бага хүүхдийн эцэг эхийн зэрэг хүнээс буюу тэжээсэн нохой эзэн хүнээсээ удаан тусгаар байж байгаад дахин уулзахдаа мэхийшрэн халж ядах зэргээр аашлах; *хүүхэд аваасаа гирэвшээд ойртохгүй байна.*

ГИТАР товшуур хөгжим.

ГИЧ I у р г а м а л иш нь өндөр, навч нь ногоон, цэцэг нь хурц шар, шар будаа мэт тослог үртэй, үрийн өнгө нь хар, хүрэн бор, улаан хүрэн, зэрлэг таримал хоёр зүйл бий, юнгар ч гэдэг; *гичийн тос;* **гичийн гоёу** (наалт хөхүүлэг); **гичийн бөөс** (гич ургамлаар идэшлэдэг нэгэн зүйл хорхой).

ГИЧ II хэлээ хөдөлгөж доод уруулыг дуугарган нохой дуудахад хэрэглэх аялга; *гич гич; гич; гичлэх.*

ГИЧГЭНЭ у р г а м а л ишгүй, газраар наалдан ургадаг олон наст ургамал, навч нь нохойн хэлний адил, гадар цагаан, дотор хөх, навчаар уул хийнэ, үндсий нь иднэ ,эмнэлэгт ч хэрэглэнэ, төрөл зүйл олон.

ГИЧИЙ угтаа нохой, эдүгээ охин чоно нохойг нэрлэх болсон, өлөгчин жингэр ч гэнэ; *халтар гичий; гичийн гөлөг.*

ГИЧИР нумны хоёр захын бэлчинд үмхүүлэн хадсан мод; *нумны гичир; юманд учир бий; нуманд гичир бий, модонд мөчир бий* з үй р.

ГИЧЛЭХ хэлээ доод уруул шүдний завсарт хүргэн ховхлон дуугарах; *нохой гичилж дуудах.*

ГИШ у р г а м а л буурцагт ургамлын нам, малын тэжээлд хэрэглэдэг нэг зүйл өвс.

ГИШГҮҮЛЭХ 1. гишгэхийн үйлдүүлэх хэв; 2. гишгэгдэх; **гүү гишгүүлэх** (гүү нийлүүлэх).

ГИШГҮҮР явах зогсох зэрэгт хөлөөр гишгэхэд тохируулан үйлдсэн шат дэвсгэр; *үүдний гишгүүр; худгийн гишгүүр; гишгүүр шат.*

ГИШГЭГДЭЛ нухагдал, дарлагдал.

ГИШГЭГДЭХ 1. гишгэхийн үйлдэгдэх хэв; 2. бусдын эрхэнд орж дарлагдах; 3. явах зорчиход гүйцэгдэх.

ГИШГЭДЭЛ гишгэлт.

ГИШГЭЛТ гишгэм.

ГИШГЭЛЭГ гишгэлэх үйлийн нэр.

ГИШГЭЛЭХ олныг гишгэх, байн байн гишгэх, олны гишгэх; *хадлангийн өвсийг битгий гишгэлээд байгаарай!*

ГИШГЭМ 1. гутлын улны хиртэй юм; *гишгэм газар; гишгэм эсгий;* 2. алхам; **алхам гишгэм** х о р ш.

ГИШГЭХ 1. юмыг хөлийн улаар дарах; *алхах гишгэх;* 2. алхах; 3. зарим амьтны отлох; *азрага гишгэх; тахиа гишгэх.*

ГИШГЭЦ 1. гүехэн ус шавар шалбаагтай газарт гишгэм гутамд тохируулан тавьсан чулуу; 2 гишгэдэл.

ГИШҮҮН 1. олон нийтийн ямар нэгэн байгууллагад санал зорил нэгдэж сайн дураар элссэн хүн; *намын гишүүн; эвлэлийн гишүүн; гишүүний бат илэрхийлэх; гишүүний татвар; гишүүний үүрэг;* 2. улсын ба олон нийтийн байгууллагуудын хурал зөвлөлгөөнд сонгогдсон хүн; *бүгд хурлын гишүүн; коллегийн гишүүн;* 3. дэлхий дахины ямар нэгэн байгууллагад багтсан улс гүрэн; *манай улс бол Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн.*

ГИШҮҮ (**Н**) амьтан ургамлын зэрэг нэгэн гол биеэс салбарласан мөчир салаа, амьтны мөч гишүүн, ургамлын мөчир гишүү.

ГИШҮҮНЭ бажууна.

ГИЮН хүндийн хэмжээ, гучин жин (18 кг,-тай тэнцэнэ).

ГИЮҮРҮҮЛЭХ гиюүрэхийн үйлдүүлэх хэв.

ГИЮҮРЭХ санаашран уйтгарлах, бодлого болох; *чи битгий гиюүрээд байгаарай!*

ГЛИЦЕРИН хувилах ухааны аргаар өөх тосны зүйлээс ялгаруулан авдаг өтгөвтөр тунгалаг шингэн зүйл; эмнэлэг, техникт хэрэглэнэ.

ГОВИЛ I юманд бий болсон нарийвтар хөнхөр хотгор; *хутганы говил; хамрын говил.*

ГОВИЛ II юманд говил гаргах дугараг иртэй багаж, ховил ч гэнэ.

ГОВИЛДОХ юманд говил гаргах; *тэр модыг говилдох үгүй юу?*

ГОВИЛДУУЛАХ говилдохын үйлдүүлэх хэв.

ГОВИЛТОХ юманд говил гарах.

ГОВИЛТУУЛАХ говилтохын үйлдүүлэх хэв.

ГОВИРХОГ говийн байдалтай; *говирхог газар.*

ГОВИРХУУ говийн шинж маягтай; *говирхуу газар тэмээ тогтоно.*

ГОВОР 1. мөчир цөөн, ац салаагүй мод; *говор ширэнгэ;* 2. морь малын хэлбэр байдал аятай нь; *говор морь.*

ГОВЧИХ I говчуур татвар авах; *алба говчих.*

ГОВЧИХ II морь малын нуруунд тохом ширдэг татахад говчуур буюу атавч мэтээр даруулан уяж торгох.

ГОВЧИХ III говчуураар загас шүүрдэн барих.

ГОВЧУУЛАХ говчихын үйлдүүлэх хэв.

ГОВЧУУР I олноос нийгэн тэсгэн татаж авах албан татвар; *албан говчуур; говчуур татвар* х о р ш..

ГОВЧУУР II 1. хоёр модонд оосор уяж гэзгэвч сагалдарга тавин ногтны оронд хэрэглэх хэрэгсэл; 2. хоёр модонд оосор уяж тэрэг чирэх малын хүзүүнд зүүх хэрэгсэл; 3. малд ширдэг тохом татахад дээгүүр нь дарж уях хоёр хавтгай мод, зарим газар атавч гэдэг; **говчуур эмээл** (тэрэг чирэх малд тохох бяцхан эрвэлжин эмээл) .

ГОВЧУУР III 1. загас хааж барих нэгэн зүйл тор өөш; *говчуур өөш;* 2. загас барих хүн сууж явдаг гуя онгоц мэт зүйл; говчуур онгоц.

ГОВЧУУРДАХ говчуураар загас барих.

ГОВЧУУРЛАХ I олноос говчуур алба авах.

ГОВЧУУРЛАХ II малын нуруунд говчуур тохож тогтоох; *морио говчуурлах.*

ГОВЧУУРЛАХ III говчуур өөш тавьж загас барих; *загас говчуурлах.*

ГОВЬ ургамал тачир сийрэг, ой мод ба урсгал ус маш ховор, элс хайрхаг хөрстэй, тарвага нутагшдаггүй хээр тал газар; *говь тал; элсэн говь; цөл говь; говь цөл; говийн өндөр модонд, голио нөмрөг донгодно хөө* (ардын дуу); ☆ **говийн шар** у р г а м а л (хужирхаг хөрстэй газар, мөн нуур бүрдийн эрэг хавиар ургадаг нэг зүйл бударгана); **говийн шар** а м ь т а н (говь газар оршдог цайвар шар өнгөтэй нэг зүйл аалз).

ГОГОД у р г а м а л сонгинын төрлийн нэг зүйл, олон наст ургамал, бог мал дуртай иднэ.

ГОГОДОХ ямар нэгэн юмыг ганц хуруу буюу гох дэгээ зэргээр дэгээдэж татах; *утас гогодох; дэгээдэж гогодох.*

ГОГОДУУЛАХ гогодохын үйлдүүлэх хэв.

ГОГОЛ у р г а м а л сараана цэцгийн язгуур, нарийн навчтай, өндөр нь 15—50 см., мараатай газар ургадаг олон наст ургамал.

ГОГООГ: гогоог гогоог тахиа гургуулын дууны аялга.

ГОГООГЛОХ эмэгчин тахиа, гургуул зэргийн гогоог гогоог гэж дуугарах.

ГОГООГЛУУЛАХ гогооглохын үйлдүүлэх хэв.

ГОГОРХОГ дэндүү хээнцэр.

ГОГОРХОХ хээнцэрлэх.

ГОГОЧ 1. тахилзуур, хээнцэр; 2. шооч.

ГОГЦОВЧ утас хэрээдэслэх хэрэгсэл.

ГОГЦОО 1. эд барааны тогтсон хэмжээгээр хийсэн бүхэл бүтэн хэсэг; *гогцоо торго; гогцоо дурдам; гогцоо утас;* 2. юмны барьж өлгөж болох сэнж буюу битүү сурвалж; *бүрх малгайн гогцоо.*

ГОГЦООЛДОХ утас, сур, дээс зэргийн оосрыг эгэлдрэн уях; *үүнийг гогцоолдон уявал сайн.*

ГОГЦООЛДУУЛАХ гогцоолдохын үйлдүүлэх хэв.

ГОГЦООРОХ юм ээдэрч гогцоо гарч сэнжтэх; *утас гогцоорох; дээс гогцоорох.*

ГОГЦООРУУЛАХ гогцоорохын үйлдүүлэх хэв.

ГОД I амьтны арьсны дөрвөн хөлийн шилбэний арьс; *нэхийн год; хурганы арьсны год; үнэгний арьсны год;* **годон малгай** (арьсны годоор хийсэн малгай).

ГОД II **год год** нялх хүүхдийг өхөөрдөн баясгахад хэрэглэх аялга; **год год хийх** (нялх

хүүхдийн баясч хоолойгоо татах, дуугарах, инээх).

ГОДВОЛЗОХ годгор юмны годос годос хөдлөх.

ГОДГО: годго годго хийх 1. годгор юмны үргэлжлэн хөдлөх байдал; 2. год год хийх.

ГОДГОДОХ 1. шингэн юмны годхийн асгарах; *гантай ус годгодоод асгав;* 2. хүүхдийг гижигдэх.

ГОДГОДУУЛАХ годгодохын үйлдүүлэх хэв.

ГОДГОЙ хонины сүүлийн нарийн үзүүр, годон ч гэнэ.

ГОДГОЙДОХ шингэн юмны олгойдож асгарах; *цоорхой хөхүүртэй айраг годгойдож байв.*

ГОДГОНОХ 1. годгор юмны годго годго хөдлөх; *сүүл нь годгонон зогсож байв;* 2. шилжсэн тогтворгүй зан байдал гаргах; *настайчууд хайхад годгоноод байх юм.*

ГОДГОНУУЛАХ годгонохын үйлдүүлэх хэв.

ГОДГОНУУР аалигүй, тогтворгүй, гэдэн годон зан байдалтай; *годгонуур хүн.*

ГОДГОР хэвийн хэмжээнээс богино шодон нарийн юм; *годгор гэзэг; годгор сүүл;* **годгор шодгор** хорш.

ГОДГОСХИЙХ годгор юмны түр зуур годойх.

ГОДИЛ I харвуулын сумны үүсгэр зэвийн завсарт хийх бяцхан болцуу; *сумны годил.*

ГОДИЛ II 1. жин дэнс зэргийн тэнгийн мод; 2. жин дэнсний туухай; *жингийн годил; дэнсний годил.*

ГОДИЛ III авд яваа хүмүүсийг арав арваар хуваахад нэг арав.

ГОДИЛ IV: **годил шуудай** нарийн жижиг шуудай.

ГОДИЛДОХ 1. годилоор харвах ба цохих; 2. хүн амьтны толгойгоороо тонгорцоглох.

ГОДОЙ: годой мах хүзүүний мах; **годой сүүл** (годон сүүл).

ГОДОЙЛГОХ годойхын үйлдүүлэх хэв; *оодонгийн үхэр сүүлээ годойлгон давхив.*

ГОДОЙХ годгор болох; *дээл нь богинодоод годойн харагдаж байна; сүүл нь годойх.*

ГОДОЛЗОХ годгор юмны годос годос хөдлөх.

ГОДОН I 1. хонины сүүлийн нарийн үзүүр годгой; *годон сүүл;* 2. морь малын сүүлний хялгас оготор буюу шингэн шодон; *годон бор морь;* **годон шодон** хорш..

ГОДОН II годрон өвчин.

ГОДОН III: **гэдэн годон** тогтвор суурь муутай; *гэрийн хойно гэдэн годон* оньсго.

ГОДОНТОХ годрон тох.

ГОДОС: годос годос хийх годгор юмны годос годос хөдлөх.

ГОДРОЙТОХ 1. юмны тонгорцоглох; *хүүхэд годройтох; чарга годройтох;* 2. шагааг алцуу буюу туухай тавьж нэгэн хуруугаар хөндөн эргүүлэх; *шагаа годройтох.*

ГОДРОЙТУУЛАХ годройтохын үйлдүүлэх хэв.

ГОДРОН ямаанд тохиолдох халдварт өвчин, энэ өвчнөөр өвдөөд эдгэрсэн ямаанд мөнхүү өвчин дахин үл тусна; *манай оронд годронг бүрэн устгаж чадав.*

ГОДРОНТОХ ямаанд годрон өвчин тохиолдох.

ГОДРОНТУУЛАХ годронтохын үйлдүүлэх хэв.

ГОДХИЙХ 1. ус зэргийн шингэн юм, нүх сүвээр гэнэт гоожих; *хамраас цус годхийв;* 2. бяцхан биет амьтад юмнаас түргэн зайлах ба гүйх; *зурам нүхнээсээ годхийж гарав.*

ГОЁ 1. үзэсгэлэнтэй, сайхан юм; *гоё сайхан; гоё дээл;* 2. гоёмсог; **ганган гоё** хорш.: **гоё үгээр мэхлэх** (урам зориг оруулах сайхан үг хэлж хуурах); ☆ **гоё өвчин** (бие махбодийн бодисын солилцоо дутагдаж, нуруу хүзүү зэрэг эрхтэн хөших өвчин).

ГОЁДОХ хэтэрхий гоё болох; *чиний дээл чинь дэндүү гоёдоод байна.*

ГОЁЛ гоёх чимэглэл хувцас; *гоёлын дээл; гоёлын малгай;* **гоёл чимэг** хорш..

ГОЁЛОГ баахан гоё.

ГОЁЛХИЙЛЭХ хээнцэрлэх.

ГОЁМСОГ гоё байдалтай болгож хээнцэрлэсэн чимэглэсэн юм; *гоёмсог хүн; гоёмсог гэр.*

ГОЁМСОГЛОХ 1. юмыг сайхан болгож янзлан чимэглэх; 2. хүний гоёчоор аашлах; *гоёмсоглон ярих.*

ГОЁМСОГМОЛОХ хуурамч гоёмсог зан ааш гаргах.

ГОЁО у р г а м а л говь газар ургадаг, үндэс нь улбар шар өнгөтэй, шүүслэг чихэрлэг амттай идшинд хэрэглэдэг; **гоёо** *түүх;* гоёо *ургах цаг.*

ГОЁТОХ гоё өвчин тусах; *тэр хүний хүзүү гоётсон байна.*

ГОЁТУУЛАХ гоётохын үйлдүүлэх хэв.

ГОЁХ юмыг үзэмжтэй сайхан болгож хээнцэрлэх, чимэх, чимэглэх; *хүүхдийг багаас нь гоёхын хэрэггүй;* **гоёх гангалах; гоёх гоодох** х о р ш . .

ГОЁХОН баахан гоё, гоёлог; *гоёхон цэцэг.*

ГОЁЧ 1. зүйг дагахгүй, шудрага бусаар засдаг хүн; 2. тал тохой татах заншилтай.

ГОЁЧГҮЙ үнэнч шудрага, засдаг зангүй.

ГОЁЧЛОХ үйл явдалд гоёч байдал гарган явах.

ГОЁЧЛУУЛАХ гоёчлохын үйлдүүлэх хэв.

ГОЖГОДОХ шингэн юмны гожгонон гоожих; *хоолойноос ус гожгодож байв.*

ГОЖГОДУУЛАХ гожгодохын үйлдүүлэх хэв.

ГОЖГОНОХ 1. шингэн юм нүх цоорхойгоор олгойдон гарах; 2. жижиг гол горхины ус шоржигнон урсах.

ГОЖГОР нарийн, гонзгор, годгор; *гожгор лонх.*

ГОЖИЙЛГОХ гожийхын үйлдүүлэх хэв.

ГОЖИЙХ гожгор болох, гожгор тогтох.

ГОЗГОНОХ гозгор юмны гозго гозго хөдлөх; *тарваганы толгой гозгонож байна.*

ГОЗГОР өндөрлөг буюу босоо зогсоо юм; *гозгор хад; гозгор оройтой малгай; гозгор эвэртэй хонь.*

ГОЗОЙЛГОХ гозойхын үйлдүүлэх хэв; *могой толгойгоо гозойлгож байв.*

ГОЗОЙХ гозгор болох; *цахилгаан мэдээний өндөр мод холоос гозойн харагдаж байна.*

ГОЗОЛЗОХ гозгор урт нарийн юмны гозос гозос хөдлөх.

ГОЗОЛЗУУЛАХ гозолзохын үйлдүүлэх хэв.

ГОЗОН I гозгор.

ГОЗОН II: гозон толгой ганц бие: *гон бие гозон толгой.*

ГОЙД онц, тасархай, гоц; *гойд сайн хүн юм; гойд дулаан өдөр боллоо.*

ГОЙДЛОХ гойд болгох; *гойдлох юм алга.*

ГОЙДОРХОХ гойдлох, илүүрхэх; *түүний чанар нь гойдорхох юм алга.*

ГОЙМОН 1. зуурсан гурилыг шүүр мэтэд шахан гоожуулж хатаасан гурил; *нарийн гоймон; хөндий гоймон; гоймонтой хуурга; гоймонтой шөл;* 2. ш и л ж с э н нарийн урт; *гоймон шиг нарийхан.*

ГОЙРОХ сойгдох, малын хоол ундны хэмжээ багадсанаас бие мах шуугдан чангарах.

ГОЛ I 1. ихээхэн урсгал ус; **гол мөрөн; гол горхи** х о р ш . ; *Хэрлэн Онон Туулын тунгалаг сайхан голууд;* **гол гарах** (гол гэтлэх); **гол захлах** (голын захаас хөлдөж эхлэх); **гол хадаалах** (голын усны гадаргыг мөс бүрхэж, хүн малын явахад цөмрөхгүй даацтай болох, гол хадаалах хугацааг мэдсэнээр тээврийн онгоц явах хугацааг зөв тодорхойлоход ач холбогдолтой байдаг); **гол унах** (хаврын цагт цөн гүйж дуусаад голын ус бүрэн цэлмэх); **голын түвшин** (голын эргийн тухайн цэгт олон жил ажиглалт хийж дундаж түвшинг олоод, тэрхүү дундаж түвшнээс дээш гарсан усны гадрага); **голын цөн** (хаврын цагт хадаалсан мөс эвдэрч хэсэгрэсэн мөс): **цөн гүйх** (цөн мөс усаар урсах); **голын хурдас** (голын урсгалын хүчинд түрэгдэн гарсан элс, шавар чулуулаг зэрэг юмс); **голын цайр** (дөнгөж өрөмтөх төдий хөлдсөн мөс зайрмаг); **голын татам** (голын усны халих, татах хэм буюу орших байр газар): **голын эх** (гол үүсгэлийн газар буюу урсгалын дээд этгээд); **голын адаг** (голын төгсгөлийн газар ба урсгалын доод этгээд); **голын эрэг** (голын хажуугийн газрын ирмэг); **голын хөвөө** (голын захын орчин газар): **голын тохой** (мөрөн голын муруйн урссан булан газар); **голын тэртээ** (голын цаад тал); **голын энтээ** (голын наад тал буюу наана); **голын цаад** (голын тэртээ тал буюу цаана): **голын наад** (голын энтэй тал); **нэг голынх** (а. нэг гол горхиноос ууж айл зэргэлдээ нутагладаг хүмүүс; б. нэг нутгийнх; *энэ бид хоёр чинь нэг голын хүмүүс байгаа юм);* 2. зарим нутагт үер борооны ус урсах ихээхэн сайр, намаг булагтай газрыг гол гэнэ; 3. хуучин гол урсаж байсан ором газар; **голын шар** у р г а м а л (голын зах, чийгтэй газраар ургадаг олон наст ургамал: багваахай

цэцгийн адил том шар цэцэгтэй); **голын хиаг** ургамал (голын хөндий, намаг мэтийн газраар ургадаг олон наст үндсэрхэг ургамал);

ГОЛ II 1. ихэнх дийлэнхийг эзэлсэн; *манай гол хоол-мах, цагаан идээ; малын гол нь хонь; ургамлын гол нь хиаг; тарианы гол нь буудай;* **гол төлөв** (их төлөв); 2. юмны дотоод төвт байгаа зүйл; *өвсний гол; тэрэгний гол; шилбэний гол; лааны гол;* **гол сүүл** (хяргуйн сүүлийн дундах хоёр урт өд); **голт зүрх, амин зүрх** (а. амьтны амин зүрх; б. хүний үр садан мэтийн дотроос хамгийн дотно хайртайгий нь; 3. төвт байгаа чухал, үндсэн зүйл; *гол гудамж; гол зорилго; гол рольд тоглох; гол утгыг үзэх;* **голы нь барих** (а. голлон явах; б. шилжсэн үнэн зөвийг баримтлах; в. дундыг баримтлах); **гол ёс** (хүн нийтийн дагавал зохих зүйл); **гол сүнс** (үйл явдлын чухамхүү ноцтой газар): **гол нуруу** (а. байшин барилгын их нуруу, ноён нуруу ч гэнэ; б. юмны ихэнх төлөвийг эзэлсэн хувь; *төлөвлөгөөт ажлынхаа гол нурууг босгов; бичих зохиолынхоо гол нурууг бичив);* **гол газар** (төвийн газар); **гол зам** (а. хүн амьтны явах зорчих төв буюу дардан их зам: б. улс нийгмийн мөрдөн дагаж явах гол зарчим зам): **гол дунд** (төв дунд, өр дунд); **гол багана** (а. байшин барилгын тулах хүчний дийлэнхийг дааж бий багана; б. үйлдэх бүтээх үйл явдалд голлон эрхэлж бий хүн): 4. хагас хувь, тэхий дундуур; *голоор нь хуваах; голоор нь аваачих; гол төвийг барих;* ☆ **гол гэсэр цэцэг** ургамал (тал хээрийн нутагт ургадаг ургамал; цэцэг хөх цэнхэр өнгөтэй, зарим нутагт хонины нүд гэх буюу мөн өнчин цэрэв ч гэдэг); **гол өвс** ургамал (голын эрэг хөндий, намаг, нуурын орчим мөн марзтай газар ургадаг олон наст ургамал, цэцэггүй): **голы нь таслах** (амий нь таслах); **гол судас, гол судал** (бие махбодийн артерийн судсыг тэтгэн тэжээх голлох том судас); **гол мах** (сээр нурууны дотор журмын дагуу голын хоёр хажуу дагуугийн зурвас мах): **гол зогоох** (өлбөрөхгүйн төдийхөн идэх).

ГОЛДОХ юмны ихэнх дийлэнх хувийг эзлэх бүтээх хүчин болох; *энэ ажлыг би голдож хийх юм.*

ГОЛДУУ юмны ихэнхийг эзэлсэн хувь; *хонь голдуу малтай; морь голдуу адуутай; намын гишүүд голдуу ажилчид.*

ГОЛДУУЛАХ голдохын үйлдүүлэх хэв.

ГОЛДЬ тооны нэр; арван сая, живаа ч гэнэ.

ГОЛИГОНОХ голигор юмны голиго голиго хөдлөх.

ГОЛИГОР хүн амьтны бие, гэдэс, хэвэл хэвийн жишээнээс бүдүүн тарган зузаалаг; *голигор тарган шар; голигор гэдэстэй хүн.*

ГОЛИЙЛГОХ голийхын үйлдүүлэх хэв.

ГОЛИЙХ голигор болох; *чи чинь ажил ч хийхгүй голийгоод л байна уу?*

ГОЛИЛЗОХ голигор юмны гольс гольс хөдлөх.

ГОЛИЛЗУУЛАХ голилзохын үйлдүүлэх хэв.

ГОЛИО амьтан царцааны төрлийн шавьж; ургамлын навч идэж хооллоно, хөдөө аж ахуйн ургамалд хортой; **үхэр голио** (том голио).

ГОЛЛОЛТ юмны гэрэл мишилд нэвтэрч, төвлөрөн голлосон цэг; **голлолт тааруулах** (гэрэл зургаар авах юмны дүр ил тодорхой үзэгдэх тэрхүү цэгийг олох).

ГОЛЛОХ 1. юмны гол төвийг олох; *голлон суух;* **голлон тоглох** (жүжиг кино мэтэд гол-лон тоглох); 2. юмыг тэхий дундуур нь хуваах; *голлон хуваах;* 3. гол болгох; *малын ажил голлох; тариалангийн ажил голлох; хоолонд ногоо голлож хэрэглэнэ;* 4. юманд гол бий болон тогтох, голтох; *ургамал голлох;* 5. усны хоёр захаараа хөлдөж эхлэх; *ус голлож байна.*

ГОЛЛУУЛАХ голлохын үйлдүүлэх хэв; *гэрийн үүдийг голлуулах.*

ГОЛОГДОЛ ямар нэг юм зохих хир хэмжээнд үл тэнхцэн шаарлагдсан нь; *гологдол гаргах; гологдол мал; гологдол ноос.*

ГОЛОГДОХ голохын үйлдэгдэх хэв, жигшигдэх, гээгдэх, орхигдох, шаарлагдах.

ГОЛОМТ 1. айлын гал түлэх тулга зуух; **гал голомт** хорш.: 2. айлын нутгийн тулга зуух байсан ором; *айлын голомт битий голло!;* 3. өвгөдийн гэр өрхийг залгамжлан яваа айл өрх; *өвгийн минь гэр голомт; аавынхаа гал голомтыг сэргээж явна би; дархан манай хувьсгалт Монгол Улс, даяар монголын ариун голомт;* **голомт сахих** (үе улирсан гал голомтоо залгамжлан эзлэх); **голомт залгамжлагч** (өв хөрөнгө залгамжлан авбал зохих хүн); **голомты нь баллах** (үр угсаагаар нь сүйтгэх); **голомт тасрах** (үе залгамжлах хүнгүй болох); 4. үүр үүсвэр; *халдварын голомт; дайны голомт.*

ГОЛОХ 1. юмыг үл тоомсорлох, үл дурлах зэргээс орхих гэх жигших шаарлах; *хүчий нь голох; ясы нь голох; царайгий нь голох;* 2. сая төрсөн мал төлөө хайрахгүй орхих; *үнээ тугалаа голох; хонь хургаа голох.*

ГОЛТОХ 1. тариа будааны баахан түүхийхэн болох; 2. тарианы түрүү гарах ойртож голын навч босох; *тариа голтох;* 3. юманд гол бий болох; *ургамал голтох.*

ГОЛУУЛАХ 1. голохын үйлдүүлэх хэв; 2. гологдох.

ГОЛЦУУ голдуу, зонхи; *голцуу манайхан ирсэн; голцуу эмэгтэйчүүд байв.*

ГОЛЧ үнэнч шудрага, чигч; *голч хүн;* **голч шугам** (дув дугуй, юмны чухам голыг тааруулан татсан чиг шугам).

ГОЛШИГ 1. зан ааль хөнгөмсөг эвээргүү; *голшиг аальтай хүн;* 2. гуа үзэмжтэй буюу хээнцэр байдалтай; *голшиг үзэмжтэй хүн.*

ГОМДОЛ өнгөрсөн хэрэгт нэхэж гунихарсан санаа; *гашуудал гомдол; харамсал гомдол; хорсол гомдол;* **гомдол эрэх** (гомдсон учраа илэрхийлэн мэдүүлэх): **гомдол гаргах** (гомдсоноо илэрхийлэн хэлэх); **гомдол тасрах, гомдол барагдах** (гомдсон үйл явдал нэгэн тийш болж гомдохоо зогсох); **гомдлын хайрцаг** (гомдол санал бичиж хийх цоожтой хайрцаг); **гомдлын товчоо** (гомдол санал барагдуулан шийдвэрлэх албан газар).

ГОМДОЛТОЙ гомдол байгаа, харамсалтай; *та гомдолтой юу?*

ГОМДООХ гомдоход хүргүүлэх; *сайн нөхрөө гомдоож болохгүй.*

ГОМДОХ өнгөрсөн хэрэг явдалд нэхэж гунирхах, гомрох, хорсох; *гашуудан гомдох.*

ГОМДУУЛАХ гомдохын үйлдүүлэх хэв.

ГОМОРХОЛ сэтгэлд үлдэж хоцорсон харамсал гомдол; *над гоморхол их байна.*

ГОМОРХОХ үйл явдалд санаа сэтгэл хангамжтай болоогүй, чамархал төрөгдөн хоцрох; *санасандаа хүрч чадаагүйдээ гоморхож байна.*

ГОМОРХУУЛАХ гоморхохын үйлдүүлэх хэв.

ГОМТГОХ гомдуулах.

ГОН I: **гон бие** ганц бие; *гон бие гозон толгой* з үй р.

ГОН II: **гон гон хийх** хүний олон үг нуршихад зэвүүрхэн муушаахад хэрэглэнэ; *чи битгий гон гон хийгээд бай!; гон гон хийсэн ямар жигтэй амьтан бэ.*

ГОНГИНОХ I хүн амьтны эе эвгүй гуншин дуугарах; *гонгиносон дуу сонсдоход тааламжгүй байдаг.*

ГОНГИНОХ II гонгонох; гон гон хийх, үглэн яншиж гонгинох.

ГОНГИНУУР үглээ, яншаа, нуршаа яриатай.

ГОНГИНУУЛАХ гонгинохын үйлдүүлэх хэв.

ГОНГОНОХ үл тоомсорлон шоодоход хэрэглэнэ; *гонгонон гуншин дуугарах; улиг домог болтол гонгоновч олсон ашиг алга.*

ГОНГОНУУЛАХ гонгонохын үйлдүүлэх хэв; *түүний дураар гонгонуулах хэрэг юу байна?*

ГОНЖ дэмий, хоосоор, огт бүтэхгүй; *чи түүнийг дийлнэ гэдэг гонж!; юмыг санасан төдийгөөр хийчихнэ гэдэг гонж!*

ГОНЖГОНОХ гонжгор юмны үргэлжлэн хөдлөх.

ГОНЖГОНУУЛАХ гонжгонохын үйлдүүлэх хэв.

ГОНЖГОР хэвийн жишээнээс баахан гонзгой хэлбэртэй юм.

ГОНЖИЙХ гонжгор болох.

ГОНЖИЛЗОХ гонжгор юмны байн байн хөдлөх.

ГОНЗГОЙ уртлаг юмны хэлбэр байдал; *нүүр нь гонзгой хэлбэртэй, нуд нь тас хар.*

ГОНЗГОР хэлбэр байдал гонзгой; *бяцхан гонзгор мод; гонзгор хэлбэртэй сав.*

ГОНЗОЙЛГОХ гонзойхыч үйлдүүлэх хэв; гонзгой болгох.

ГОНЗОЙХ гонзгор болох, гонзгор харагдах.

ГОНСГОР сэтгэл санаанд нийлэмж тохиромжгүй үйл явдал тохиолдож урам хугарах, мохох, гутрах; *сэтгэлд нэг л гонсгор байна.*

ГОНСОЙЛГОХ гонсойхын үйлдүүлэх хэв; гонсгор болгох.

ГОНСОЙХ гонсгор болох, гонсгор харагдах.

ГОНСРОХ гансрах, сэтгэл гутах.

ГОНТОГ у р г а м а л төрөл зүйл 100 орчим; 1—2, мөн олон настай ч байдаг, цэцгийн өнгө ихэнхдээ шар байдаг, заримыг эмнэлэгт хэрэглэнэ.

ГОНТОХ хүний илэрхий бус аргаар биедээ ашиг олж завшихыг хичээн шунахайрах.

ГОНХЛОХ гонхон болгох; **гэр гонхлох** (хоёр гэр холбож барих).

ГОНХОН сүм дуганы дотор гадар ямар нэг газарт нь өрөө тасалгаа маягтайгаар барьсан сав; *бурхны гонхон; үүдний гонхон.*

ГОНШГОНОХ 1. улиглан гуйж уйлах; 2. улиглан үглэн шаардах; 3. гон гон дуугарах, гонгонон ярих.

ГОНШГОНУУЛАХ гоншгонохын үйлдүүлэх хэв.

ГОНШИХ гунших.

ГОНЬД ургамал шүхэр цэцгийн нам, жижиг мөхлөг үртэй, цагаан цэцэгтэй нэг наст ургамал.

ГОО гоё; *гоо сайхан; гоо цэцэг.*

ГООГЛОХ шувууны гоог гоог гэж дуугарах; *тахиа гооглох.*

ГООДОХ гоёх, янзлах, **гоёх гоодох** х о р ш . .

ГООЖИН ойгоос мод огтлох тухай зохих газраас олгосон зөвшөөрлийн бичиг; *модны гоожин авах; гоожингийн татвар.*

ГООЖИНХОЙ сав суулга зэргийн юмны цоорхой; *гоожинхой хувин.*

ГООЖИРХОЙ гоожинхой.

ГООЖИХ шингэн буюу нарийн ширхэгт юмны асгарах цуврах; *тос гоожих; цус гоожих; будаа гоожих;* **шүлс гоожих** (шүлс савирах): **гоожих угаагуур** (нүүр гар угаах хэрэглэл).

ГООЖУУЛАХ гоожихын үйлдүүлэх хэв; *ус гоожуулах; нусаа гоожуулах;* **хөлсөө гоожуулах** (а. ядарч хөлс нь гоожих; б. ш и л ж с э н хөдөлмөрлөх; *бид хөлсөө гоожуулж байж олсон юм*) в. ш и л ж с э н шунах; *эд юманд шүлсээ гоожуулах.*

ГООЖУУР гоожуулах хэрэглэл; *усны гоожуур.*

ГООМОЙ даамай биш ,мөчид дутмаг, хөнгөн хийсвэр юм; *ажлыг гоомой хийж болохгүй; гоомой хүн.*

ГООМОЙДОХ хэтэрхий гоомой болох.

ГООМОЙЛОХ юмыг гоомойд үзэх.

ГООМОЙРОХ гоомой болох; *чи гоомойрч болохгүй.*

ГООМОЙТОХ үйл явдалд даамай биш байдал гаргах; *битгий гоомойтоорой, лавхан шиг барь.*

ГООНОГОР хүний нуруу ганагар ба амьтны хүзүү урт бөгөөд гэдгэр; *гооногор нуруутай; гооногор хүзүүтэй.*

ГООНОЙХ гооногор болох.

ГООНЬ гэргийгүй насжисан эрэгтэй хүн; *гоонь ганц; гоонь эр.*

ГООРХОГ хээнцэрлэх дуртай; *гоорхог хүн;* **гоорхог хээнцэр** х о р ш . .

ГООРХОХ хээнцэрлэн явах.

ГООЧ I горь, горьдлого; **гооч горьдлого** х о р ш . ; *гоочтой хэрэг гоочтой хүн;* **гоочоо алдах** (горьдлого барагдах): **гооч тасрах** (горьдлогогүй болох).

ГООЧ II хээнцэрлэх зантай.

ГООЧ III бусдыг зориуд өдөөж зүгээр байлгадаггүй зантай хүн; *тэр хөрш гооч хүн шүү.*

ГООЧГҮЙ горьдох найдах зүйл огтгүй, горьдлого тасарсан; *би гоочгүй болов.*

ГООЧЛОХ 1. хүн амьтны юмыг бага сага оролдож эхлэх буюу хангалттай биш оролдох; *хүүхэд, бор хоол гоочлох санаатай байна; хурга ишиг өвс гоочилж байна; би зүгээр суухаар гэж аар саар юм гоочилж л сууна;* 2. хүн, бусдыг элдвээр өдөж оролдох буюу өө сэв эрэлхийлэн ухчилж оролдох; *чи намайг гоочлох хэрэггүй, хувиа хичээ.*

ГООЧЛУУЛАХ 1. гоочлохын үйлдүүлэх хэв; 2. гоочлогдох.

ГООЧТОЙ горьдлоготой, найдвар бий; *тэр гуай тун ч гоочтой хүн.*

ГОРДГОР горзгор.

ГОРДОЙЛГОХ гордойхын үйлдүүлэх хэв.

ГОРДОЙХ гордгор болох.

ГОРЗГОР 1. нарийн бөгөөд өндөрхөн юм; *горзгор туранхай хүн; горзгор мод;* 2. хатаж хатуурсан юм; *горзгор борц; горзгор сүр.*

ГОРЗОЙЛГОХ горзойхын үйлдүүлэх хэв.

ГОРЗОЙХ горзгор болох, горзгор харагдах.

ГОРИГҮЙ 1. нэгэнт горь тасарсан; *олох горигүй* 2. болохгүй, бүтэхгүй; *аа, горигүй байх гэж санаж байна;* 3. хэцүү бэрх; *горигүй хүн; горигүй хэрэг.*

ГОРИЛОХ үйл явдлыг өөрийн хүссэнээр болоосой гэж хүсэх горьдох; *намайг сургуульд явуулж өгөх болов уу гэж горилж байна.*

ГОРИМ ямар нэгэн юмны тогтсон ёс дэглэм; **горим журам; ёс горим** х о р ш..

ГОРЛОС Өвөр Монголын нэгэн аймаг.

ГОРОЙЛГОХ горойхын үйлдүүлэх хэв.

ГОРОЙХ идсэн уусан юмны тээглэж хадуулдах ба санаанд тохиромжгүй явдал тохиолдон бодлого болох; *хоол горойх; санаа ширч горойх; дотор горойх.*

ГОРОЛЗОХ байн байн горойх.

ГОРОО юмыг эргэн тойрох; *гороо хийх; гороо эргэх.*

ГОРТИГ I дугуйлан зурах буюу хэмжих багаж, зурах үзүүрийг хөдөлгөн их бага янз бүрийн хэмжээтэй дугуй зурж болно; **гортиг хэрэгсэл** (шугам зураг зурахад зориулсан бүрэн багаж).

ГОРТИГ II дугуй зураас; **гортиг татах** (дугуй этэг татаж зурах); ☆ **гортиг яр** (цус саатсанаас болж бэлхүүс орчин гарах яр).

ГОРТИГДОХ гортигоор зураг зурах.

ГОРТИГЛОХ 1. гортигдох; 2. тойруулан зурах, дугуйлах.

ГОРХИ I хэл бүхий гархи; *олонгийн горхи; бүсний горхи.*

ГОРХИ II жижиг урсгал ус; **гол горхи** х о р ш.

ГОРХИЛОХ I юмыг горхиор торгох.

ГОРХИЛОХ II усны горхилон урсах.

ГОРХИЛУУЛАХ горхилохын үйлдүүлэх хэв.

ГОРЬ 1. горьдлого, хүсэл; *санасан зүйл гүйцэлдэх горь бий; нэгэнт горь тасрав;* 2. юмны сайны хувь үлэмж давуу; *горьтой чадамгай; горьтой мэргэн.*

ГОРЬДЛОГО горь, хүсэл, гооч; *горьдлого тасрав.*

ГОРЬДЛОГОГҮЙ горь тасарсан, горьдсоны гарз; *ямар ч горьдлогогүй болжээ.*

ГОРЬДОМТГОЙ горьдомхой.

ГОРЬДОМХОЙ бүсдаас горьдох зантай; *горьдомхой хүүхэд; горьдомхой нохой.*

ГОРЬДООХ горьдоход хүрүүлэх; *чи намайг бас сурхий их горьдоосон шүү.*

ГОРЬДОХ горилох, горилон хүсэх, итгэн найдах; *нөгөө номоо авчирсан байх гэж горьдов.*

ГОРЬДУУЛАХ горьдохын үйлдүүлэх хэв.

ГОРЬТОЙ горь гооч бий, найдвар бий; *би ч горьтой шүү.*

ГОРЬЧ горьдомхой; *горьч зантай хүн билээ.*

ГОРЬЧЛОХ завшаан эрж горилон явах.

ГОСПИТАЛЬ цэргийн эмнэлгийн газар; *госпиталд эмчлүүлэх.*

ГОХ 1. бууны замаг буулгах дэгээ; *бууны гох;* 2. юмыг тээглэх өлгөх хэрэгсэл; *дэӭдэх гох; сав суулга өлгөх гох; унжлага чимэг зүүх гох;* 3. мэх заль, гох мэх; *мэх гох нь хэтэрсэн.*

ГОХДОХ 1. гохоор дэгээлэх, торгох, өлгөх; 2. бусдыг арга хэрэглэн биедээ татах.

ГОХДУУЛАХ 1. гохдохын үйлдүүлэх хэв; 2. гохдогдох.

ГОХЛОХ 1. гохдох; 2. хүний харилцан егөөдөж ярилцах; *зүгээр ярьж болдоггүй юм үү? ямагт гохолж байхын хэрэг юун.*

ГОХОВЧ худраганы салаалжийн язгуурт хадсан гохт төмөр.

ГОХТОЙ арга мэх ихтэй; *тун болдоггүй гохтой хүн.*

ГОЦ онцгой, хэтэрхий; *гоц сайн; гоц муу; гоц морь;* ☆ **гоц мөргөх** (бөхийн хий мөргөх).

ГОЦДОХ 1. гоцлох; *бөх гоцдох;* 2. хэтэрхий гоц болох.

ГОЦЛОЛ гоцлох үйлийн нэр; *гоцлол хөгжим; гоцлол дуу.*

ГОЦЛОХ I бөх барилдахад хэдэн даваа өнгөрсний хойно өрөөсөн үлдвэл нэгэн хүнийг хий мөргүүлж давсанд тооцох; *бөх гоцлох; гоц мөргөх;* 2. онцлох, гоц болгох.

ГОЦЛУУЛАХ 1. гоцлохын үйлдүүлэх хэв; 2. гоцлогдох.

ГОШИЙХ өвс ургамал зэргийн юмны гулзайн унах.

ГОЮУ эм бүхий хөхүүлгийн зүйл; шарх, хавдар, идээ бүхий газар наалдуулан тавина; *гоюугаар хөхүүлэх.*

ГӨВДӨХ гөвөх, гөвших, дэлдэх, цохих; *саваагаар гөвдөх .*

ГӨВДРҮҮ гөвгөр юмс; *биед гөвдрүү гараад байна; гөвдрүүтэй газраар явахад төвөгтэй байдаг.*

ГӨВДРҮҮТЭХ гөвдрүү бий болох, гөвдрүү гарах.

ГӨВДҮҮЛЭХ 1. гөвдөхийн үйлдүүлэх хэв; 2. гөвдөгдөх.

ГӨВИЙХ гувийх, гөвгөр болох, гувайх.

ГӨВШИХ гөвдөх, дэлдэх, гөвөх.

ГӨГИЙ хурууны үзүүр идээлэн өвчлөх өвчин.

ГӨГИЙРҮҮЛЭХ гөгийрэхийн үйлдүүлэх хэв; гөгийрэхэд хүргүүлэх

ГӨГИЙРӨХ гөгий яр гарах.

ГӨГИЙТӨХ гөгийрөх, гөгий өвчин тохиолдох.

ГӨГИЙТҮҮЛЭХ гөгийтөхийн үйлдүүлэх хэв.

ГӨГӨСГӨНӨ у р г а м а л азаргана гэдэг ургамлын үндэс, хүн иднэ.

ГӨЕН гүн биш, мөчид; *гөен ус; гөен углуурга.*

ГӨЕДӨХ хэтэрхий гөен болох.

ГӨЕХӨН баахан гөен; *гөехөн ус; эрдэм сурлаги гөехөн; ажлын чадвар гөехөн; гөехөн болох.*

ГӨЛБӨЛЗӨХ 1 гэм хийсэн хүний нүүр жүлчилзэж гэмшсэн байдал гаргах; 2. гөлөлзөх, гөлгөнөх.

ГӨЛГӨНӨХ 1. гөлгөр юмны гөлөг гөлөг хийх, гулгариа байдал биед сэрэгдэх үзэгдэх; 2. ам шаагдаж мухардах; *хэлэх үггүй гөлгөнөх.* • •

ГӨЛГӨР өө сэвгүй гулгариа; *гөлгөр мөс; гөлгөр хад; шил мэт гөлгөр.* •

ГӨЛЖ: гөлж борын цэцэг у р г а м а л хотын цэцэрлэг зэрэгт тарьж ургуулдаг бутархаг ургамал; цэцэг том, өнгө улаан цагаан зэрэг бий, цэцгийн үнэр маш сайхан.

ГӨЛИЙЛГӨХ 1. гөлийхийн үйлдүүлэх хэв, гөлгөр болгох; 2. жишимгүй байдал гаргах; *юу ч болж байсан гөлийлгөж суудаг хаашаа хүн бэ, чи!*

ГӨЛИЙХ 1. гөлгөр болох; *мөс гөлийх;* 2. ширтэн харж гөлрөх; 3. жишим ч үгүй суух; *гөлийсөн сурхий хүн.* •

ГӨЛМИЙ загас агнахад хэрэглэх их өөш; *гөлмий өөш.*

ГӨЛМИЙДӨХ гөлмийгөөр загас агнах.

ГӨЛӨГ I зарим араатан амьтны зулзага; *чонын гөлөг; нохойн гөлөг.*

ГӨЛӨГ II модны сая соёолон цухуйсан навч; *бургасны гөлөг.*

ГӨЛӨГЛӨХ I 1. чоно нохойн төрөх; *нохой гөлөглөх;* 2. ш и л ж с э н тоглоом наадмын зэрэгт дараа дараагаар олон юм цувуулан гаргах; *даалуу гөлөглөх ;хөзөр гөлөглөх.*

ГӨЛӨГЛӨХ II модны гөлөг гарах; *бургас гөлөглөх.*

ГӨЛӨГЛҮҮЛЭХ гөлөглөхийн үйлдүүлэх хэв.

ГӨЛӨЛЗӨХ 1. гөлгөр юмны гөлс гөлс хийх, биед сэрэгдэх; 2. гөлбөлзөх.

ГӨЛӨЛЗҮҮЛЭХ гөлөлзөхийн үйлдүүлэх хэв, гөлөлзөхөд хүргүүлэх.

ГӨЛӨМ 1. монгол эмээлд байдаг тусгай бэлтгэгдсэн олом жирмийн халхавч жийрэг; үүнийг арьс шир, хивс, даавуугаар хийнэ; *ширэн гөлөм; хивсэн гөлөм;* 2. гөлөм хийхэд зориулан боловсруулсан дөрвөлжин шир буюу бусад эд бараа; *гөлөмний шир; гөлөмний хивс;* 3. зарим юмны нэгэн ширхэг нимгэн хуудас; *гөлмөн төмөр; гөлмөн шил.*

ГӨЛӨНГӨР бөс бараа, хөвөнгөөр хийнэ, будаг цардуулаар гилгэр болгоно, их төлөв зураг зурахад хэрэглэнэ.

ГӨЛРӨӨ гөлрөх өвчин олсон нь; *гөлрөө өвчтэй хүн.*

ГӨЛРӨХ I 1. нүдний аньсга цавчлага ба нүдний хөдөлгөө нь цөөрөн ширтэлхилэх; *ном уншсаар нүд гөлрөх; мод ширтсээр гөлрөв;* 2. юмны улам исэх хүч нь буурч сулрах; *айраг гөлрөх;* 3. буцалж оргилж байсан юм зөөлөрч намжин гүйлгэнэх; *цай гөлрөх.*

ГӨЛРӨХ II юманд бодлого болж алмайран дүйрэх, гөлрөө болох; **гөлөрдөг өвчин** (номой, дорой болж, хөдлөх явах нь хойрго болох өвчин).

ГӨЛРҮҮЛЭХ гөлрөхийн үйлдүүлэх хэв. гөлрөхөд хүргүүлэх.

ГӨЛТГӨНӨ өнгө цагаан, зөөлөн чанарын чулуулаг; шатааж барилга, баримал, эмнэлэг зэрэг зүйлд хэрэглэнэ.

ГӨЛЧГИЙ I зарим жижиг амьтны зулзага; *оготны гөлчгий*

ГӨЛЧГИЙ II модны салаанаас салбарласан үрийн ширхэг; *бургасны гөлчгий.*

ГӨЛЧГИЙЛЭХ I жижиг амьтны төрөх; *зурам гөлчгийлэх.*

ГӨЛЧГИЙЛЭХ II модны салаанаас салбарлан гарсан үрийн улам цааш үржин гарах, гөлөглөх ч гэнэ.

ГӨЛЧГӨР гөлгөр, гулгараа.

ГӨЛЧИГНӨХ 1. гөлчгөр юмны гөлчиг гөлчиг хийх ба биед сэрэгдэх; 2. гөлөгнөх.

ГӨЛЧИЙЛГӨХ гөлчийхийн үйлдүүлэх хэв, гөлчгөр болгох.

ГӨЛЧИЙХ гөлчгөр болох, толигор болох; **гөлийх гөлчийх** х о р ш..

ГӨЛЧИЛЗӨХ 1. гөлчгөр юмны гөлчис гөлчис хийх ба биед сэрэгдэх; 2. гөлөлзөх, толилзох .

ГӨМС юмны зохих бололцох хэм барагт үл хүрэлцэх буюу дутуу мөчид чамлалтай болох; *үйлдсэн бүтээсэн нь хэврэг гөмс; утга санаа нь мөчид гөмс; гүйцэх хүрэлцэхгүй дутмаг гөмс.*

ГӨМСДӨХ хомсдох, мөчдөх, дутах.

ГӨМСЛӨХ гөмсөд үзэх, мөчид санах.

ГӨМСХӨН баахан гөмс, маш гөмс; *сэтгэлд гөмсхөн байна; гөмсхөн сурлагатай хүн.*

ГӨНЖИХ юмыг гөнжүүрээр дээш болгох; хөших гөнжих х о р ш.; *гөнжиж өргөхөд хялбар байдаг.*

ГӨНЖӨӨ саахуу гэдэг сав.

ГӨНЖҮҮЛЭХ 1. гөнжихийн үйлдүүлэх хэв; 2. гөнжигдөх.

ГӨНЖҮҮР юм хумыг өргөж дээш болгох зэрэгт хэрэглэх хөшүүр зэвсэг; **хөшүүр гөнжүүр** х о р ш..

ГӨНТЭЙ егөөтэй; *хашир гөнтэй хүн;* **гөнтэй жинтэй** х о р ш..

ГӨРДӨӨЧ гөрч, гүжирч.

ГӨРДӨХ 1. худал зүйлээр бусдыг бурангуйлан гүтгэх; 2. жанчих, цохих.

ГӨРДҮҮЛЭХ 1. гөрдөхийн үйлдүүлэх хэв; 2. гөрдөгдөх.

ГӨРЛӨГ гөрдөхийн тулд хийсэн ажиллагаа. •

ГӨРЛӨӨ сүлжээ, гөрсөн нь; *гэзэгний гөрлөө; дээсний гөрлөө; гөрлөө сайтай жирэм.*

ГӨРЛӨӨЧ гөрч, гүжирч.

ГӨРЛӨХ гөрдөх, гүжирдэх.

ГӨРМӨЛ гөрж хийсэн юм; *гөрмөл гэзэг; гөрмөл утас; гөрмөл ташуур.*

ГӨРМӨЛИЙ улаалж өвс.

ГӨРӨЛЧ гөрч.

ГӨРӨӨ ан амьтан; **ан гөрөө** х о р ш.; *ан гөрөө хийх.*

ГӨРӨӨЛӨХ ан амьтан агнахаар явах.

ГӨРӨӨЛҮҮЛЭХ гөрөөлөхийн үйлдүүлэх хэв.

ГӨРӨӨС махчин биш, өвсөн тэжээлтэн зэрлэг том амьтад; *бор гөрөөс; сүүлтэй гөрөөс: бух гөрөөс.*

ГӨРӨӨЧИН анч, анчин; **гөрөөчин** (ан гөрөөгөөр амьдардаг хүн); **анчин гөрөөчин** х о р ш..

ГӨРӨӨЧЛӨХ гөрөөлөх; *ууланд гөрөөлж явлаа.*

ГӨРӨХ сур дээс, утас, хялгасны зэрэг юмыг гурваас доошгүй ширхэг хэсэг болгож солбицон сүлжих; *гэзэг гөрөх; жирэм гөрөх;*

ГӨРҮҮЛЭХ гөрөхийн үйлдүүлэх хэв; *гэзэг гөрүүлэх.*

ГӨРЧ бульхайлах, гөжирдөх зантай; *гөрч хүн.*

ГӨХИЙ ишинд шижим холбого, дэгээ уяж загас барих зэвсэг, одоогийн загасны дэгээ.

ГӨХИЙДӨХ гөхийгөөр загас барих.

ГӨХИЙДҮҮЛЭХ гөхийдөхийн үйлдүүлэх хэв.

ГӨХӨЛ 1. хүн ба малын голгойд хэсэглэн үлдээсэн үс; *хүүхдийн гөхөл; морины гөхөл;* **гөхөл тавих** (толгойд хэсэг үс үлдээж орхих): 2. шувуу зэрэг зарим амьтны дух ясанд ургасан өд үс; *шувууны гөхөл.*

ГӨХӨЛДӨХ гөхлөөс нь барих.

ГӨХӨЛДҮҮЛЭХ 1. гөхөлдөхийн үйлдүүлэх хэв; 2. гөхөлдөгдөх.

ГРАДУС 1. тойрог буюу өнцгийг хэмжих нэгж; тойргийн 360-ны 1-тэй тэнцэнэ; *90 градусын өнцөг;* 2. халуун хүйтнийг хэмжих багаж зэрэг юмны хувиар; *20 градус дулаан.*

ГРАММ метрийн системийн хэмжүүрийн жингийн нэгж, нэг шоо дөрвөлжин сантиметр усны жинтэй тэнцэнэ; *500 грамм мах; 200 грамм талх.*

ГРАНАТ дэлбэрдэг жижиг бөмбөг; **гар гранат** (нэг зүйл авсаар гранат).

ГРАФИК 1. тоо чанар, өсөлт бууралтыг үзүүлсэн зураас бүхий хүснэгт; 2. ажлын төлөвлөгөөний биелэлтийг нарийвчлан тэмдэглэсэн зураг, мөн хийх үйлдэх юмны цаг хугацаа зэргийг тодорхойлсон зурмаг; *галт тэрэгний хөдөлгөөний график.*

ГУА I сэтгэл дурнаа зохистой үзэмжтэй гоо сайхан юм; *гуа сайхан; гуа үзэсгэлэн; гуа жавхлан;* **гуа сайхны зүй** (урлагийн хөгжил, үүсэл, мөн чанар, зарчим, ерөнхий зүй тогтоол тэргүүтнийг судлах ухаан); **гуа сайхны хүмүүжил** (хүмүүсийг гуа сайхны зүй ёсоор хүмүүжүүлэх).

ГУА II у р г а м а л шаравтар буюу ногоон өнгөтэй, хэлбэр бөөрөнхий, том, амттайхан усархаг жимс; хальс хатуу; *амтат гуа;* **ший гуа** (тарвас).

ГУАГ зарим амьтны дуу; *хэрээ гуаг гуаг* дуугарав; *мэлхий гуаг гуаг гэж байна.*

ГУАГЛАХ зарим амьтны гуаг гуаг дуугарах; *хэрээ гуаглах; мэлхий гуаглах.*

ГУАГЛУУЛАХ гуаглахын үйлдүүлэх хэв.

ГУАЙ 1. ах настныг хүндлэх аялга; *ах гуай; Насан гуай;* 2. дээд тушаалын хүнийг хүндэтгэхэд хэрэглэнэ; *сайд гуай; дарга гуай.*

ГУАЙЛАХ бусдыг хүндэтгэн тэр гуай, энэ гуай гэж дуудах.

ГУАЙЛУУЛАХ гуайлахын үйлдүүлэх хэв.

ГУАЛИГ үзэмжтэй, аятай; *гуалиг морь; гуалиг хүн.*

ГУАЛИН мөчир дурсы нь мөлж зассан бүдүүн урт мод; *барилгын гуалин; гуалин байшин; гуалин гүүр.*

ГУАМИН өлгөмөл шиш, гоймон ч гэнэ; *хөндий гуамин; нарийн гуамин.*

ГУАНЗ I хоол ундны зүйлийг боловсруулан худалдаалах газар; *сувиллын гуанз.*

ГУАНЗ II лимбэтэй төстэй бөгөөд богино, бийв хийж үлээж дуугарах нэгэн зүйл хөгжмийн зэвсэг.

ГУАНЗДАХ I гуанзанд орж хооллох, хоол идэх.

ГУАНЗДАХ II гуанз хөгжим дуугаргах.

ГУАНЗДУУЛАХ гуанздах I II-ын үйлдүүлэх хэв.

ГУВАЙ эмэгтэй хүний зүс байдал үзэсгэлэнтэй сайхан; *гувай хүүхэн; гувай дагина*

☆ **гувай хатан** у р г а м а л (маш хортой эмийн ургамал; булчин шөрмөс татахад хэрэглэнэ); **гувай цэцэг** у р г а м а л (удвал цэцгийн адил, хэлтэс дан, хүрэн цагаан хоёр зүйл бий).

ГУВАЙЛГАХ гувайхын үйлдүүлэх хэв, гувайхад хүрүүлэх.

ГУВАЙХ гувгар болох, гувгар харагдах.

ГУВГАР уртхан гөвгөр юм; *гувгар газар; гувгар хамар.*

ГУВЖ бурантаг уяагаа хаздаг тэмээ, нохой зэргийн амьтны бурантаг уяаны угт залгасан мод буюу төмөр; *гувжтай нохой.*

ГУВЖЛАХ тэмээ нохой зэргийн бурантаг уяанд гувж хийх.

ГУВЖЛУУЛАХ гувжлахын үйлдүүлэх хэв.

ГУВРАХ ургамлын гулжилзан ганхах найгах; *мод гуврах; цэцэг гуврах.*

ГУВРУУ I туранхилсан тэмээний хамрын дотоодод товойн хавдаж мөгөөрс болон гуврах өвчин; *гувруу өвчнөөр өвчилсөн тэмээ.*

ГУВРУУ II нарийн юмаар жанчигдсан цохигдсоны ором товойн хавдсан гөврөө.

ГУВРУУТАХ I гувруу өвчин тусах.

ГУВРУУТАХ II гувруу гөврөө гарах.

ГУВЧГАНАХ гувчгар амьтны гавчга гавчга хийх.

ГУВЧГАР хэвэл нарийн мэхгэр хавчгар, туранхай; *гувчгар морь; гувчгар хүн.*

ГУВЧИЙХ гувчгар болох.

ГУВЧИЛЗАХ гувчгар юмны гавчис гавчис хийх.

ГУВЧИХ говчих I II III.

ГУВЧУУЛАХ говчуулах.

ГУВЧУУР говчуур I II III.

ГУВЧУУРДАХ говчуурдах.

ГУВЧУУРЛАХ говчуурлах I II III.

ГУВШАА өөрийн эхийн хөхийг хэтэрхий ховдоглон хөхөх буюу бусдын эхийн хөхийг хулуун хөхөх зантай нялх бага амьтан; *гувшаа хүүхэд; гувшаа хурга.*

ГУВШИХ нялх бага амьтны ховдоглон гувшин хөхөх; *хурга гувших;* ☆ **гуйж гувших** (ичгүүргүй улиглан гуйх).

ГУВШУУЛАХ гувшихын үйлдүүлэх хэв.

ГУД хүч нэмэгдүүлэх үг; *гуд татах; гуд дайрах; гуд сорох.*

ГУДАЙЛГАХ гудайхын үйлдүүлэх хэв; гудгар болгох.

ГУДАЙХ 1. юмны нэгэн этгээд хажуу тийшээ жиших, доошдох, гудгар болох; *нар гудайх; дэр гудайх;* 2. юмны хэвийн байдлаас дордох, муудах; *хөрөнгө гудайх; толгой гудайх.*

ГУДАМ нарийн чөлөө зай; *байшингийн гудам; гудмын хивс.*

ГУДАМЖ эгнэсэн хашаа барилга, түүний заверын шулуун чөлөө; *аршааны гудамж; усны гудамж; гудамж орон сууцны хороо* (хот суурин газрын захиргааны нэгж, хорин).

ГУДАМЖЛАХ гудамж болгох; **гудамжлан зогсох** (хоёр эгнээ жагсан зогсож, хоорондоо нарийн зай гаргах).

ГУДАМЖЛУУЛАХ гудамжлахын үйлдүүлэх хэв, гудамж болгох.

ГУДАРГАН юмны толгой цээжийн зүг хөнтөргөн хэлтгий; *гударган ор; гударган дэр.*

ГУДАРГАНДАХ хэтэрхий гударган болох.

ГУДАРХИЙЛАХ 1. сайн мууг ялгаварлахгүй дэмий шургалан явах; 2. хүний дэмий тэнүүчлэн явах.

ГУДАС I явдлын далим дашрам; *зам гудас; очих зам гудасдаа хүргэж өгье.*

ГУДАС II нарийн уртхан ширдэг дэвсгэр; *орны гудас; ширмэл гудсаа тавиад өг.*

ГУДАСЛАХ гудас болгох.

ГУДГАР юмны цээжин тал буюу явах зорчих зэрэгт өмнөд этгээд, дор нам буюу хөнтөргөн хэлтгий; *гудгар цээжтэй морь; гудгар газар.*

ГУДГАРДАХ хэтэрхий гудгар болох.

ГУДИГ 1. гуниг; *гудаг төрөв;* 2. тоомсор. хайхрамж.

ГУДИГГҮЙ I. гуниггүй; 2. тоомсоргүй, хайхрамжгүй, анхааралгүй; *гудиггүй царай гаргасан хачин хүн.*

ГУДИГГҮЙДЭХ хэтэрхий гудиггүй байдал гаргах.

ГУДИГГҮЙТЭХ гудиггүй царай гаргах.

ГУДРАГА I юманд гурви гаргах бяцхан харуул.

ГУДРАГА II нохойн гудчих өвчин.

ГУДРАГАДАХ I гудрагаар гурви гаргах.

ГУДРАГАДАХ II гудраган хөнтөргөн нь нэндэх.

ГУДРАГАТАХ гудрага өвчин олох.

ГУДРАХ I 1. юмны нүх сүв рүү юмаар чичих; *ам руу нь модоор гудрах;* 2. шилжсэн; ховдоглон идэх; завших.

ГУДРАХ II гудчих.

ГУДРУУЛАХ I. гудрахын үйлдүүлэх хэв; 2. шургуулах.

ГУДУЙ ургамал монголын хангай хээр талын бүслүүрээр ургадаг өдөрхүү хэлбэрийн навчтай, бамбай хэлбэртэй баг цэцэг бүхий нэг зүйл олон наст ургамал.

ГУДЧАА хамар нармайдаа байн байн хий чаргагдуулан дуугарах зантай амьтан; *гудчаа хурга; гудчаа нохой.*

ГУДЧИХ I юмыг байн байн гудрах.

ГУДЧИХ II амьтны хамар нармайдаа хий чаргагдуулан дуугарах; *нохой гудчих.*

ГУДЧУУЛАХ гудчих I II-ын үйлдүүлэх хэв.

ГУЙВАЛДАХ олон юмны гуйвах.

ГУЙВАЛЗАХ гуйвгар юмны гуйвас гуйвас хийх.

ГУЙВАНГ амьтан шар шувуутай адилхан бөгөөд бие бяцхан нэг зүйл шувуу.

ГУЙВАХ I мөнгө юм энд өгч тэнд авах, тэнд өгч энд авах; *таны зардал өнөөдөр гуйвсан.*

ГУЙВАХ II 1. юмны дайвж найгах; *салхинд мод гуйвах; хөл гуйвж дайвах;* 2. хүний сэтгэл зорилго бусдын нөлөөнд татагдаж автагдах зэргээр өөрчлөгдөн хувирах; *аядан дагалдаж гуйвах; автагдан нөлөөлөгдөж гуйвах;* 3. гажуудуулах; *утгыг гуйвуулах; агуулгыг гуйвуулах.*

ГУЙВГАНАХ 1. гуйвгар юмны гуйвга гуйвга хийх; 2. гуйвах II, гайхаж гуйвах, тогтворгүй гуйвах.

ГУЙВУУЛАХ I мөнгө юмыг энд өгч тэнд авах ба тэнд өгч энд авахад хүргүүлэх; *мөнгө гуйвуулах.*

ГУЙВУУЛАХ II гуйвах II-ын үйлдүүлэх хэв, гуйвахад хүргүүлэх.

ГУЙВУУЛЛАГА гуйвуулах үйлийн нэр; *гуйвууллагын баримт.*

ГУЙГУУР үнэн үгээ хэлдэггүй хүн; *гуйгуур хүн.*

ГУЙГУУРЛАХ чухам үнэн үгээ хэлэхгүй өөрчлөн хувиргаж хэлэлцэх; *гуйгуурлах зангшилтай хүн.*

ГУЙГЧ гуйсан этгээд.

ГУЙЛАНЧИН 1. гуйдаг этгээд; 2. хөрөнгө ядуу;

ГУЙЛАНЧЛАХ гуйлгачлах, гуйранчлах.

ГУЙЛАНЧЛУУЛАХ гуйланчлахын үйлдүүлэх хэв, гуйланч болгох.

ГУЙЛГА гуйх үйлийн нэр; *гуйлга гуйх; гуйлга хийх.*

ГУЙЛГАЛАХ гуйлга хийн явах ба байн байн гуйх.

ГУЙЛГАХ 1. гуйхын үйлдүүлэх хэв; 2. гуйгдах.

ГУЙЛГАЧИН гуйранчин.

ГУЙЛТ гуйх үйлийн нэр; *гуйлт хийх.*

ГУЙЛХИЙЛЭХ байн байн гуйх.

ГУЙМТГАЙ гуймхай.

ГУЙМХАЙ гуйхдаа шаламгай, гуйх зантай; *гуймхай мөртөө голомхой.*

ГУЙРАНЧ (ИН) 1. хөрөнгө хогшил юу ч үгүй ядуу хүн; 2. гуйж амьдрагч.

ГУЙРАНЧЛАХ гуйланчлах, гуйлгачлах; гуйранч болох.

ГУЙХ бусдад хүслээ илэрхийлэн эрэх хүсэх; *өршөөл гуйх; тусламж гуйх; чөлөө гуйх;* **гуйх түүх** х о р ш . .

ГУЛАСГАХ гулсахын үйлдүүлэх хэв; гулсахад хүргүүлэх.

ГУЛБИГАНАХ 1. гулбигар юмны гулбига гулбига хөдлөх; 2. хүний тогтворгүй зан байдал гаргаж гуйвах.

ГУЛБИГАР 1. тэнхээ тамир муутай, яданги дорой амьтан; *гулбигар хүн; гулбигар дорой мал;* 2. уян нарийн, хөдөлгөхөд хялбархан гуйвдаг юм; *гулбигар мод; гулбигар төмөр.*

ГУЛБИЙЛГАХ гулбийхын үйлдүүлэх хэв, гулбигар болгох.

ГУЛБИЙХ гулбигар болох.

ГУЛБИЛЗАХ гулбигар юмны гулбис гулбис хийх.

ГУЛБИЛЗУУЛАХ гулбилзахын үйлдүүлэх хэв.

ГУЛГАЛТ гулгах үйлийн нэр; *цанын гулгалт болов.*

ГУЛГАМТГАЙ гулгамхай.

ГУЛГАМХАЙ гулгахдаа хялбар юм; *гулгамхай ултай гутал.*

ГУЛГАРАА халтираатай газар; **гулгараа халтираа** х о р ш..

ГУЛГАРАХ 1. гулгаж халтирах, гулсах; 2. хүний хэлэлцэхэд дүрвэлгүй ярих.

ГУЛГАХ 1 .гилгэр өө сэвгүй юманд буюу хажуу гулгал газар зэрэгт халтирах гулсах; *шал дээр гулсах; цанаар гулгах; тэшүүрээр гулгах;* 2. нэгээс нөгөөд шилжих; *ахын хувцас дүүдээ гулгах.*

ГУЛГИДАС гулгихад гарсан зүйл.

ГУЛГИУЛАХ гулгихын үйлдүүлэх хэв.

ГУЛГИХ 1. идсэн уусан юм төдий л хүчлэн огихгүйгээр буцаж гарах; 2. бага хүүхдийн бөөлжих.

ГУЛГУУЛАХ гулгахын үйлдүүлэх хэв.

ГУЛГУУР гулгахад зориулсан газар буюу түүнд хэрэглэх хэрэгсэл **мөсөн гулгуур** (тэшүүрээр гулгахад зориулан бэлтгэсэн мөсөн талбай); *гулгуур мод.*

ГУЛД хөндлөн биш, уртаашаа байгаа юм; **хөндлөн гулд** х о р ш.; **гулд хоног** (газрын бөмбөрцгийн умарт өмнөд хоёр туйлын оройг холбон татсан шугам).

ГУЛДААХ гулдахын үйлдүүлэх хэв.

ГУЛДАЙЛГАХ гулдайхын үйлдүүлэх хэв, гулдгар болгох.

ГУЛДАЙХ гулдгар болох; *зам дээр гуалин гулдайж хэвтэнэ.*

ГУЛДАН 1. туйпуу мод зэргээр матриулан хийсэн дугараг нуруутай хаалга; *гулдан хаалга;* 2. гүүрийн дорхи матриулан хийсэн газар; *гулдан хөндий;* 3. замын доогуур ус урсгахаар хийсэн нүх; *гулдан нүх.*

ГУЛДАНГАТАХ морь малын хүзүү нуруу бөхийж чадахгүй болох.

ГУЛДАХ бусдыг дотуур эвдэн уруу татах.

ГУЛДАЧ 1. тагнуулч; 2. бусдыг уруу татагч.

ГУЛДГАР харахад дүр төлөв уртлагхан юм; *Тэр гулдгар юу вэ?*

ГУЛДМАЙ 1. гулдгар дүр төлөвтэй юм; *гулдмай мөнгө; барилгын гулдмай;* 2. гулууз мах.

ГУЛДРАХ юм хумыг чирч татах; *чирэх гулдрах; татаж гулдрах.*

ГУЛДРИЛ 1. хүн бусдыг уруу татсаныг нь; 2. ус шурган урсах газар; *гулдрил сайр*; 3. гүүр ба далангийн доогуур хийсэн ус урсах нүх; *далангийн гулдрил; гүүрний гулдрил.*

ГУЛДРИХ 1. бусдыг ил далд аргаар уруу татах; *түүнд гулдирч замаа алдахад хүрч байна;* 2. усны газрын доогуур шурган урсах; *ус гулдрих;* 3. ш и л ж с э н бөөн ягцуу юман дундуур зүсэн орох; *хүмүүсийн дундуур гулдрин явах.*

ГУЛДЧИХ 1. байн байн гулдрих; 2. хүний сандчих.

ГУЛЖВАЛЗАХ нарийн гулжгар юмны гулжис гулжис хийх.

ГУЛЖГАЙ гулжгар.

ГУЛЖГАНАХ гулжгар юмны гулжга гулжга хийх, нахигнах.

ГУЛЖГАР хэвийн хэмжээнээс нарийн буюу хатан чийрэггүй уян зөөлөн юм; *гулжгар уургa гулжгар мод.*

ГУЛЖИЙЛГАХ гулжийхын үйлдүүлэх хэв, гулжгар болгох.

ГУЛЖИЙХ гулжгар болох, нахийх

ГУЛЖИЛЗАХ 1. гулжвалзах, нахилзах; 2. гурвалзах

ГУЛЗАЙЛГАХ гулзайхын үйлдүүлэх хэв, гулзайхад хүргүүлэх.

ГУЛЗАЙХ далжийж гулзгай болох; *буугийн гол төмрийг гулзайтал цохисон байна.*

ГУЛЗАЛЗАХ нарийн гулзгар юмны гулзас гулзас хийх.

ГУЛЗВАЛЗАХ гулзгар юмны байн байн гулзайх.

ГУЛЗГАЙ нэг тийшээ муруй тахир нарийн урт юм, *гулзгай саваа; гулзгай хайч.*

ГУЛЗГАНАХ гулзгар юмны гулзга гулзга хийх.

ГУЛЗГАР гулзгай.

ГУЛИР гурил.

ГУЛРАЛ гутал, гундрал; **гулрал гундрал х о р ш.**

ГУЛРАХ хүний ажил явдал буруутаж гундрах сүйрэх.

ГУЛРУУЛАХ 1. гулрахын үйлдүүлэх хэв; 2. гулрагдах.

ГУЛСААХ гулсахад хүргүүлэх.

ГУЛСАЛ гулсах үйлийн нэр.

ГУЛСАХ I гулгах, халтирах; *гулсаж унах мөсөн дээр гулсаж наадах.*

ГУЛСАХ II ээлж халаатай ажил, халж авах ээлжийн этгээд үл ирэх зэргээс уул ажлаа ухран үргэлжлүүлэх; *манаанд гулсах; дежүрт гулсах;* 2. нэг юм нөгөөд шилжих; *ахын дээл дүүдээ гулсах*

ГУЛСГАЛ гулсгах үйлийн нэр.

ГУЛСГАХ гулсах I II-ын үйлдүүлэх хэв, гулсахад хүргүүлэх.

ГУЛТАХ халил буюу халтираа газар, гулсах, гулгарих, тэшин унах.

ГУЛТАЧ уул хаднаас гулсаж өнхөрч ирсэн юм; *гултач чулуу.*

ГУЛТГАЛ 1. дээд нь цавчим өнгийм буюу орой нь хянга, доод нь зав суваг мэтээр хавчсан халтирам унам аймшигтай бэрх газар; *гултгал газар явахдаа маш болгоомжил!;* 2. гулсгал.

ГУЛТГАХ 1 .гултахын үйлдүүлэх хэв; 2. гулсгах

ГУЛУУЗ I гурил элдэх моголцог мод, ганжин ч гэнэ.

ГУЛУУЗ II 1. бог малын дэлгээгүй бүтэн мах; *хонины гулууз;* 2. бод малын шулж гулдан болгосон мах; *үхрийн махны тал гулууз.*

ГУЛУУЗ III гулдмай хэлбэртэй юм; *гулууз мөнгө.*

ГУЛУУЗЛАХ 1. хонь ямааны мах цээж бөгс болгон салгахгүй бүхэл хэвээр байлгах; 2. гулдмай болгох.

ГУНА (Н) зарим амьтны эр хүйст гурван настай; *шүдлэн гуна; гунан барс; гунан ирвэс.*

ГУНГАНАХ 1. мал ижил буюу төлөө өхөөрдөн дотнолж дуугарах; *үнээ тугалаа өхөөрдөн гунганаж байв*; 2. нармайгаараа гонгонон дуугарах; *гунганах дууны аюул даа;* 3. үглээ, яншаа, авад салж өгдөггүй хүнийг шоодоход хэрэглэнэ; *тэр дандаа чингэж гунганаж байдаг жигтэй хүн шүү.*

ГУНДААХ гундахын үйлдүүлэх хэв, гундахад хүргүүлэх.

ГУНДАХ 1. морь малын ихэд эдлэгдсэнээс эцэж ядрах ба жалхаа муудах; 2. хүний их

л ядангиран доройтох ба явдал буруутаж гулрах, гундах, доройтох; **гутах гундах** х о р ш . .

ГУНДМАЛ гундах үйлийн нэр; *тэр чинь гундмал амьтан болжээ.*

ГУНЖ зарим амьтан эм хүйст гурван настай; *тарлан гунж; гунжин үнээ; гунжин тэмээ.*

ГУНЖГАР хэвийн жишээнээс нарийн гонжгор урт юм; *гунжгар шуудай.*

ГУНЖИЙЛГАХ гунжийхын үйлдүүлэх хэв, гунжийхад хүрүүлэх.

ГУНЖИЙХ 1. гонжгор болох; 2. гулжийх.

ГУНЗАЙЛГАХ гунзайхын үйлдүүлэх хэв.

ГУНЗАЙХ гонзойх.

ГУНЗГАЙ гонзгой.

ГУНЗГАР гонзгор.

ГУНИА санаашрал болсон үйлийн нэр.

ГУНИАЛ санааширч гомдсон санааг тэмдэглэн бичсэн бичиг; *гуниал зохиол.*

ГУНИАХ 1. гунихын үйлдүүлэх хэв, гунихад хүрүүлэх; 2. гуниглах.

ГУНИГ сэтгэлийн зовнил, гунирал гомдол; *гунигтай явдал тохиолдов; гуниг төрөх.*

ГУНИГАЛЗАХ гунигаа огт орхихгүй.

ГУНИГАХ гуниглах.

ГУНИГГҮЙ 1. огт гунирхах байдалгүй буюу тоохгүй; *гуниггүй хүн;* 2. чадамгай сайн, дутуу муугүй юм; *гуниггүй хурдан морь; гуниггүй сайхан бичээч.*

ГУНИГЛАЛ гуниглах үйлийн нэр; *гуниглалд автагдан сууж байв.*

ГУНИГЛАХ гуних; *гуниглан ширтээд яах вэ.*

ГУНИГЛУУЛАХ гуниглахын үйлдүүлэх хэв

ГУНИГТ гуниг бүхий; *гунигт явдал бүү тохиолдог; гунигт сэтгэл.*

ГУНИГТАЙ гуниг бий болсон; *гунигтай хэрэг; гунигтай явдал.*

ГУНИГШИХ гуниглах байдал тохиолдох *гунигших сэтгэлээ орхи.*

ГУНИЛТАЙ гунивал зохилтой; *түүнд аргагүй гунилтай явдал тохиолдож билээ.*

ГУНИХ ямар нэгэн зүйлд санаашран байн байн гомдох; *гуниж гутахын хэрэггүй.*

ГУНИХРАХ өнгөрсөн үйл явдлыг нэхэн санаж гутах гуних.

ГУНИХРУУЛАХ гунихрахын үйлдүүлэх хэв

ГУНСРАХ 1. гансрах, гундах; 2. гулрах, доройтох.

ГУНСРУУЛАХ гунсрахын үйлдүүлэх хэв.

ГУНХАЛЗАХ гунхгар юмны гунхас гунхас хөдлөх.

ГУНХАЛЗУУЛАХ гунхахын үйлдүүлэх хэв.

ГУНХАХ гунхгар болох.

ГУНХВАЙ: гунхвай цэцэг у р г а м а л намуу цэцгийн язгуурын ургамал, цэцэг нь цагаан буюу ягаан өнгөтэй гоёмсог том.

ГУНХГАНАХ гунхгар янзлаг юмны гунхга гунхга хийх.

ГУНХГАР үзэмжтэй аятай; *гунхгар сайхан нуруутай хүн; гунхгар аятайхан уурга.*

ГУНШАА хамар нармайгаар дуугардаг; *гуншаа хүн.*

ГУНШГАНАХ 1. байн байн гунших; 2. хүний дэмий олон үг нуршин ярих, шоодон хэлэх; *чи битгий гуншганаад байгаарай.*

ГУНШГАНУУЛАХ 1. гуншганахын үйлдүүлэх хэв; 2. үлээвэр хөгжмийн зөөлөвтөр гоншгонуулан дуугаргах.

ГУНШИН нэр зэрэг; алдар цол; *гуншингаа дуудуулах.*

ГУНШИХ 1. гуншаа хүний дуугарах; 2. хүний дорой дуугаар нуршин хэлэх; *олон үг гунших хэрэггүй.*

ГУНШУУЛАХ гуншихын үйлдүүлэх хэв.

ГУР бор гөрөөсний эр.

ГУРАВ (ГУРВАН) тооны нэр, хоёр дээр нэгийг нэмсэн нь; *чи надаас гурав дүү; гурав дахин их хэмжээтэй юм; хоёрдугаар сарын гурван; арван гурван; гурван жил; гурван давхар; гурван зуу;* **гурван үүд** (бие, хэл, сэтгэл); **гурван хар** (тачаангуй, урин ,мунхаг); **гурван самшуу** (зүрх ходоод хоёрын хоорондохийг дээд самшуу, ходоодны дундахыг дундад сам-

шуу; хүйс давсгийн хоорондохийг доод самшуу); **гурван марал** з у р х а й (сарны зурхайн 28 одны дотоод Марксар од); **гурван амттан** (бал, бурам, чихэр): **гурван цаг** (өнгөрсөн, одоо, ирээдүй); **гурван цэг** х э л з ү й (цэг тэмдэг); **ертөнцийн гурав** (монгол ардын аман зохиолын нэг төрөл); **гурван цагаан** (өсөхөд шүд цагаан, өтлөхөд үс цагаан, үхэхэд яс цагаан); **гурван хоосон** (бүрин тавин боловч зүүд хоосон, барайж торойж байвч зэрэглээ хоосон, бархирч чарлаж байвч цуурна хоосон); **гурван сөгдөл** х у у ч и р с а н (хишигт мөргөхөд гурвач үе сөгдөж, гурван үе босох); **гурван сайн заяа** (тэнгэр, хүн, асурь); **гурван муу заяа** (там, бирд, адгуусан).

ГУРАВДАХ 1. юмны гурван удаа дахих буюу болох; *хоёр удаа очоод уулзсангүй тул гуравдахдаа учрав;* 2. хүний санаа явдал хоёрын хооронд гурвын дунд болох; *хоёрдох гуравдах.*

ГУРАВДАХЬ дэс тооны гуравдугаар; *гуравдахь этгээд; гуравдахь хүн.*

ГУРАВДУГААР дэс тоо, гуравдахь; **гуравдугаар сарын найман** (олон улсын эмэгтэйчүүдийн баярын өдөр); *гуравдугаар боть; гуравдугаар гурил; гуравдугаар зэрэг.*

ГУРАВТ I гурван юмыг төлөөлсөн нэг юм; *гуравтын цаас.*

ГУРАВТ II гурав дахь, гуравдугаар.

ГУРАВЧ нумны элгэнд, бариулын тус газар өнгөлөн наасан яс, эвэр.

ГУРАЛЗАХ нарийн урт юмны муриганан гурвэлзэн хөдлөх; *гуралзан хөдлөх.*

ГУРАЛЗУУЛАХ гуралзахын үйлдүүлэх хэв.

ГУРАМСАН гурван ширхгээр нь багцалсан буюу нийтгэсэн юм; *гурамсан хүйв; гурамсан дээс; гурамсан утас.*

ГУРАМСЛАХ юмыг гурамсан болгох.

ГУРАМСЛУУЛАХ гурамслахын үйлдүүлэх хэв.

ГУРАНГИДАХ хэтэрхий гуринх болох.

ГУРАНЗ багаж зэвсэг хурцлах ширүүн билүү.

ГУРАНЗДАХ гуранзаар билүүдэх хавирах.

ГУРАНЗДУУЛАХ гуранздахын үйлдүүлэх хэв.

ГУРАНХЛАХ амьтны өлсч маш доройтох; *нохой гуранхлах; морь гуранхлах.*

ГУРАНХТАХ 1. гуранхлах; 2. өлбөрч идэж чадахгүй болох.

ГУРВААД түгээл тоо, гурав орчим, тусбүр гурав.

ГУРВАЛЖ у р г а м а л усанд ургадаг, гурвалжин иштэй нэг зүйл өвс.

ГУРВАЛЖИН 1. харилцан огтлолцсон гурван шулуунаар хязгаарлагдсан дотоод гурван өнцөг бүхий хэмжих ухааны дүрс; 2. гурван өнцөг буюу хушуутай, гурван тал хэлбэртэй юм; *гурвалжин хуурай; гурвалжин мод; гурвалжин чий;* **гурвалжны судлал** (гурвалжны функцийг судлах ухаан, хэмжих ухааны зүйлд багтана).

ГУРВАЛЖЛАХ гурвалжин болгох.

ГУРВАЛЖЛУУЛАХ гурвалжлахын үйлдүүлэх хэв

ГУРВАЛЗАХ урт нарийн юмны муралзан гуралзан явах хөдлөх; *могой гурвалзах; дээс гурвалзах.*

ГУРВАЛЗУУЛАХ гурвалзахын үйлдүүлэх хэв.

ГУРВАНТАА гурван удаа.

ГУРВИ 1. юманд гарсан говил; *гурвитай ширээ; хутганы гурви;* 2. юманд говил ховил гаргадаг багаж.

ГУРВИДАХ гурви гаргах.

ГУРВИДУУЛАХ гурвидахын үйлдүүлэх хэв, гурви гаргуулах.

ГУРВИТАХ гурви гарч харагдах.

ГУРВУУЛ хам тоо; *гурвуул ирэв; гурвуул хүчин хавсарч хийнэ.*

ГУРГАЛДАЙ а м ь т а н байдал тагтааны адил, бие бага, жиргэх нь гайхамшигтай сайхан, жимс ба хорхой шавьж иднэ, эрэгчин эмэгчин ээлжлэн өндгөө дарна; алтан гургалдай ч гэдэг.

ГУРГАР нарийн урт хэлбэртэй юм; *гургар дээс.*

ГУРГУУЛ а м ь т а н байдал тахианы адил, бие охор, хушуу бяцхан, өнгө хурц, сүүл урт, газрыг ухаж үүр барина, жижиг амьтан, ургамлын үр иднэ; **гургуулын сүүл** у р г а м а л (ойд хүй хүйгээр ургадаг нэг зүйл өвс, чийрс ч гэж нэрлэдэг); **гургуулын тор** (олноороо хамтарч гургуул авлахад хэрэглэх том тор).

ГУРЗАЙЛГАХ гурзайхын үйлдүүлэх хэв.

ГУРЗАЙХ гурзгар болох.

ГУРЗАЛЗАХ гурзгар юмны байн байн хөдлөх.

ГУРЗГАНАХ гурзгар юмны үргэлжлэн хөдлөх.

ГУРЗГАР туранхай хэрзгэр, нарийн, туя муутай; *гурзгар туранхай хүн; гурзгар нарийн уурга.*

ГУРИАТАХ амьтны идэш хоолгүй болон өлбөрөхөд хүрэх; *нохой гуриатах; гуриатсан чоно.*

ГУРИГ тэнхээ тэсвэр муутай' яданги дорой байдал; *гуриг морь; гуриг нохой.*

ГУРИЛ үр тарианы ургамлыг талхалж хийсэн идэшний зүйл; *овёсны гурил; цагаан гурил; төмсний гурил; нэгдүгээр гурил; дуут гурил;* **гурил элдэх** (гурил хөвөрлөх); **гурил хөвөрлөх** (гурилыг хөвөр модоор хавтгайлах); **гурил татах** (тариаг тээрэмдэн гурил хийх); **арвайн гурил** (болсон гурил); **болсон гурил** (хуурсан тариаг талхалсан гурил); **гурилын комбинат** (гурил боловсруулах үйлдвэр); **нүглийн нүдийг гурилаар хуурах** (юмыг оронцоглон халхалж өнгөрөөх); **гурилын цох** а м ь т а н (гурил иддэг нэгэн зүйл хорхой).

ГУРИЛДАХ 1. юманд гурил түрхэх, юмыг гурилд хутгах; 2. цай хийцлэх; *цай гурилдах.*

ГУРИЛДУУЛАХ гурилдахын үйлдүүлэх хэв.

ГУРИЛШИХ тариа будаа талхлагдаж гурилтай болох буюу гурил шинжтэй болох.

ГУРИНХ зарим амьтны өлсч туранхай болсон; *гуринх нохой.*

ГУРИНХЛАХ гуринх болох; *чоно гуринхлах.*

ГУРИНХТАХ гуринх байдалтай болох.

ГУР: гур бөх у р г а м а л хөдөө аж ахуйн нэг зүйл ургамал, будаа мэт үртэй, үрийг үр хэвээр нь буюу гурил болгон хэрэглэнэ.

ГУТААР а м ь т а н урт нарийн биетэй, арьсандаа бидэр мэт толботой нэг зүйл махчин загас.

ГУТААХ гутахын үйлдүүлэх хэв, гутахад хүргүүлэх; *эд танихгүй хүн, эдийн нэрийг гутаах; нэрээ гутаах; эд хэрэглэлийг эвдэж гутаах; ялзруулж гутаах.*

ГУТАГ 1. сэггэлийн шаналал; *гутаг олох;* 2. биед олсон ямар нэгэн согог; *гутаг суух.*

ГУТАЛ хөлд оймсны гадуур өмсөх түрийтэй хувцас; *гутал өмсөх; гутлаа тайлах; эсгий гутал; савхин гутал; монгол гутал гутлын ул; гутлын өсгий;* **гутлын боом** (зулаг түрий хоёрын уулзар): **гутлын хавчаар** (зулаг түрий хоёрын завсар хавчуулсан юм); **гутлын хэвлүүр** (гутал хийхэд хэрэглэх хөлийн хэлбэр бүхий хэлбүүр мод); **гутлын зуузай** (гутлын өсгийн дотор талд тавих хатуулга); **гутлын тэвчээр** (зулаг ул хоёрын завсар барьж хавчуулсан юм); **гутлын фабрик** (гутал хийх үйлдвэр); **гутлын тос** (гутал шаахайг өнгөлөх тос).

ГУТАЛТАЙ гутал бүхий, гутал өмссөн; *орон дээр гуталтайгаа хэвтэж болохгүй.*

ГУТАЛЧ (ИН) гутал хийдэг засдаг хүн; *гуталчинд очиж гутлаа хадуулав.*

ГУТАМШИГ олонд жигшигдэх муухай үйл явдал; *нэрээ хугалахаас илүү гутамшиг байхгүй.*

ГУТАРЬ 1. язгуурын сайн хүний сайн явдал эвдрэх; *сайн нь саарч гутарь болсон амьтан;* 2. санаашран зовних; *санааны гутарь болсон хүн.*

ГУТАХ 1. буурч доройтон зовних; *нэр гутах; сэтгэл гутах; өнгө нь гутах;* 2. юмны чанар муудах; *идэшний нөгөө муудаж гутах;* **дур гутах** (дургүй болох); **ой гутах** (гутамшигтай юм сэрэгдэн ихэд зэвүүцэж жигшин дургүйцэх).

ГУТГААР гуравдугаар; *гутгаар дэвтэр; гутгаар боть.*

ГУТРААХ гутрахын үйлдүүлэх хэв, гутрахад хүргүүлэх.

ГУТРАХ ямар нэгэн буурал тохиолдож доройтох, гутах; *сэтгэл гутрах.*

ГУТРУУЛ савны амсрыг хуниаслах нарийн оосор; *хавтганы гутруул.*

ГУТУЙ: гутуй мах хүзүүний мах.

ГУУ I суваг шуудуу, жалга; **суваг гуу; гуу жалга** х о р ш..

ГУУ II юм агуулах сав жааз; *зургийн гуу; гуутай хөрөг.*

ГУУ III х у у ч и р с а н эхнэр хүний хувцсан дээр зүүх нэгэн зүйл чимэг; *гуу чимгээ зүүсэн эхнэр.*

ГУУ IV албан бичгийн товч утга зэргийг гэмдэглэсэн тусгай нүүр; *бичгийн гуу; гуугийн бичээч.*

ГУУГЛАХ 1. холоос нарийн чанга дуугаар хашгиран дуудах; 2. хурдны морь унасан хүүхдийн гингуулах; 3. тахиа зэрэг шувууны гууг гууг гэж дуугарах.

ГУУГЛУУЛАХ гууглахын үйлдүүлэх хэв.

ГУУЖ жигүүр өд нь гуужин зулгарсан шувуу.

ГУУЖИХ амьтны хуучин үс арьс өд зэрэг нь зулгаран унах; *хонь гуужих; тахиа гуужих; могой гуужих; арьс гуужих.*

ГУУЛАХ 1. зураг хөргийг гуу жаазад хийх; 2. албан бичгийн товч утга зэргийг бичгийн тусгай нүүр дээр учир бүртгэн тэмдэглэх; *бичиг гуулах.*

ГУУЛИН гуулиар хийсэн; *гуулин хөгжим; гуулин шанага.*

ГУУЛУУЛАХ гуулахын үйлдүүлэх хэв.

ГУУЛЬ зэс хорголж хольж хийсэн хиймэл төмөрлөг, өнгө шар цагаан хоёр зүйл бий; **гууль нь цухуйх** (муу муухай нь илрэх).

ГУУР 1. мал гөрөөсний нурууны арьс махны завсар үүдэн төрөх хорхой; *ухрийн гуур; бугын гуур;* 2. сав суулганы зэрэг юманд гарсан нүх цоорхой; хөхүүрийн гуур; данхны гуур.

ГУУРАЙХ 1. хүний царай зүс баахан муудаж буурах; 2. морь малын хагсарч гэдэс хэвэл нарийн болох.

ГУУРС дотроо хөндийтэй нарийн урт юм; *өвсний гуурс; хий гаргах гуурс;* **өдний гуурс** (шувууны өдний язгуур); **отгоны гуурс** (малгайн өд өрөвлөг хатгах хонгио); **амьсгалын гуурс** (юманд уур амьсгал оруулах хонгио); **тарианы гуурс** (хадсан тарианы язгуур иш); **цэцгийн гуурс** (зулгарсан цэцгийн язгуур); **гуурсан бишгүүр** (хэлбэр дүр нь бишгүүрийн адил болоод богино, есөн нүхтэй).

ГУУРТАХ 1. амьтны биед гуур хорхой бий болох; 2. сав суулга мэтийн юмны цоорон нүхтэх; 3. чухал хэрэгцээт юм дуусч, ихэд дутагдах; *мөнгөгүй гууртах; давсгүй гууртах.*

ГУЦАХ дутагдах гачигдах; **дутах гуцах хорш..**

ГУЦУУ дутуу; **дутуу гуцуу хорш..**

ГУЧ (ИН) I 1. тооны нэр, гурван арав нийлсний нийлбэр; *таван зургаа гуч; эр хонь гуч; гучин тав; гучин хоёр давхар; гучин километр;* 2. сарын эцсийн гучдугаарт тохиолдох өдөр, битүүн ч гэнэ; *нэгдүгээр сарын гучинд би хөдөө явна.*

ГУЧ II жичид төрсөн хүүхэд; *миний гуч болох хүүхэд.*

ГУЧААД түгээл тоо, тус бүр гуч, гуч орчим.

ГУЧДУГААР дэс тооны гучид тохиолдсон нь; *гучдугаар талд үз.*

ГУЧИНТАА гучин удаа.

ГУЧИНЦАР гучид төрсөн хүүхэд; *миний гучийн хүүхэд болохлоор над гучинцар болно.*

ГУЧУУЛ хам тоо, гучин тоотой; *бид гучуул ирэв; гучуул бүрэн бий.*

ГУШГАНАХ гушилзах, гангалах.

ГУШГАР хэвийн жишээнээс нарийвтар гулжгар юм; *гушгар нарийн өндөр нуруутай хүн; гушгар нарийн гуйвалган уурга.*

ГУШИЙЛГАХ гушийхын үйлдүүлэх хэв.

ГУШИЙХ 1. гушгар болох; 2. гушгар юмны гулжийн унах; *зам дээр уурга гушийж хэвтэнэ.*

ГУШИЛЗАХ гангалах, хээнцэрлэх.

ГУШУУН гашуун эхүүн амт.

ГУЯ 1. амьтны сүүжнээс шилбэний дээд үе хүртлэх хэсэг; *хонины гуя;* **гуя ганзгалж ирэх** (юу ч үгүй хоосон ирэх); 2. зарим юмны өрөөсөн тал; *хаалганы гуя; хайчны гуя; тэрэгний гуя;* 3. мөрөн гол усыг гэтлэхэд хэрэглэх бяцхан онгоц; *гуя онгоц;* 4. гуя хөхрөх өвчин; *хөх гуя.*

ГУЯДАХ 1. унасан морь мал зэргийг ташуур мэтийн юмаар гуяны тус газар жанчих дэлдэх; *морио гуядсаар ирэв;* 2. буздыг ямар нэгэн юмаар савах, дэлдэх; *эх нь хүүхдээ бусээрээ гуядаад авав;* 3. тэрэг чарга мэтэд урт юмыг ташуу хөндлөн тавьж ачих, гуялах ч гэнэ; *гуалин модыг гуядаж ачих хэрэгтэй;* 4. бөхийн мэх, барилдсан бөхийн нэг нь нөгөөгөө хүчтэйгээр савж хаях; *гуядаж унагаах.*

ГУЯДУУЛАХ гуядахын үйлдүүлэх хэв.

ГУЯЛАХ 1. гуядах ;*гуялж ачих;* 2. махнаас гуяыг салгах; *мах гуялах;* 3. гуятах; *хөх гуялах.*

ГУЯТАХ гуя өвчин тохиох; *хөх гуятах.*

ГҮВ усны гүн газар; *усны гүвийг болгоомжил.*

ГҮВГЭНҮҮЛЭХ гүвгэнэхийн үйлдүүлэх хэв.

ГҮВГЭНЭХ 1. зарим жижиг амьтны явах хөдлөх; *хорхой гүвгэнэх;* 2 .хүний дорой байдалтайгаар гүвнэн хөдлөх; *арай л гэж гүвгэнэж явна даа;* 3. биен дээр жижиг амьтны явж хөдлөх нь сэрэгдэх; *нуруун дээр юм гүвгэнээд байна.*

ГҮВГЭР товгор, тэгшээс өчүүхэн өндөр бөгөөд бяцхан уртлаг байдалтай юм; *тэр харагдаж байгаа гүвгэр нурууны цаана айл бий.*

ГҮВДРҮҮ 1. биед гарсан бяцхан бяцхан товгор цадал; *биед гүвдрүү гараад байна;* 2. *гөвгөр төвгөр газар; гүвдрүүтэй газраар явахад төвөгтэй байдаг.*

ГҮВДРҮҮТЭХ биед гүвдрүү гарах.

ГҮВДЭХ жанчих, дэлдэх, гүвэх; *саваагаар дээлээ гүвдэв.*

ГҮВИЙХ гөвгөр болох, гүрвийх; *жанчигдсаны ором гүврээ гүвийж харагдав.*

ГҮВНЭХ 1. жижиг амьтны явах хөдлөх нь биед сэрэгдэх; *хорхой гүвнэх;* 2. ямар нэгэн амьтны маш аажмаар гэлдрэн явах: **гүвнэх гэлдрэх** х о р ш.. .

ГҮВРЭЭ жанчигдсан шүргэгдсэн зэргийн оромд гарсан ор тэмдэг; *саваадуулсан гүврээ арилаагүй.*

ГҮВРЭЭТЭХ гүврээ гарах ба загаднасан газрыг маажихад мөр гаргах; *бие гүврээтэх.*

ГҮВҮҮЛЭХ 1. гүвэхийн үйлдүүлэх хэв; *тоосоо гүвүүлэв;* 2. гүвэгдэх.

ГҮВҮҮР юм хумын хог тоос, шороо зэргийг арилгаж цэвэрлэх хэрэгсэл; шувууны өд, үхэр адууны сүүл хялгас, бөс даавуу мэтийг тусгай ишид тогтоон хийнэ; *өдөн гүвүүр; хялгасан гүвүүр; гүвүүрийн иш.*

ГҮВҮҮРДЭХ шороо тоос зэргийг гүвүүрээр цохиж арилгах.

ГҮВЭХ I юманд наалдаж хуралдан тогтсон шороо тоос мэтийг сажих, сэгсрэх, дэлдэх зэргээр арилгах; *дээл гүвэх; дэвсгэр гүвэх; тоос гүвэх; хормойгоо гүвэх.*

ГҮВЭХ II хөрөнгө юмаа бүрэлгэн барах; *байдаг хөрөнгөө гүвсэн өөдгүй амьтан; амныхаа хишиг буянг гүвэх хэрэггүй.*

ГҮВЭЭ I уртлаг гүвгэр газар, зарим нутагт намхан нуруу гүвээ гэнэ; *тэр гүвээн дээгүүр морьтой хүн гарч ирлээ;* **даваа гүвээ** х о р ш..

ГҮВЭЭ II тариа ногооны газар хийсэн далан.

ГҮГЭЛ зандан модны давирхай; *гүглийн үнэр анхилж байв.*

ГҮДГЭР хотгор гэдгийн эсрэг утга; *гүдгэр* газар; *гүдгэр нуруу.*

ГҮДИЙЛГЭХ гүдийхийн үйлдүүлэх хэв, гүдгэр болгох.

ГҮДИЙХ 1. гүдгэр болох; 2. горойх.

ГҮДЭС шулуун эршүүд, түвшин томоотой; *гүдэс хүн; гүдэс зан.*

ГҮДЭСДЭХ дэндүү гүдсийн үчир тохиромжгүй болох.

ГҮДЭСХЭН баахан гүдэс.

ГҮЕН адууны хамрын гадаад ирмэгийн орчинд нарийн мөгөөрс товойн гардаг өвчин.

ГҮЕНТЭХ адуунд гүен өвчин гүсах.

ГҮЖИР I хилс, гөрдөл; **гүр гүжир, хилс гүжир** х о р ш.; *гүжрийн үгэнд харшулах бэрх.*

ГҮЖИР II дөжир товир, тэсвэр сайтай, бат чийрэг юм; **гүжир дүжир; гүжир товир** х о р ш. *гүжир эр; гүжир морь.*

ГҮЖИРДҮҮЛЭХ гүжирдэхийн үйлдүүлэх хэв.

ГҮЖИРДЭХ гөрлөн гүтгэх, мэлзэх; *улайн цайн гүжирдэв.*

ГҮЖИРЛЭХ I хүн амьтны дөжирлөж хатуужин явах.

ГҮЖИРЛЭХ II гүжирдэх, гүтгэх.

ГҮЖИРМЭГ гүжирмэгий

ГҮЖИРЭМГИЙ үйл явдалд шийдэмгий, зоримог зантай; *ажилд гүжирмэгий хүн*

ГҮЖИРМЭГИЙЛЭХ хүний гүжирмэгий зан байдал гаргах.

ГҮЖИРМЭГЛҮҮЛЭХ гүжирмэглэхийн үйлдүүлэх хэв.

ГҮЖИРМЭГЛЭХ үйл явдалд гүжирмэг байдал гарган явах хөдлөх.

ГҮЖИРМЭГЭЭР хатуу бэрх үйл явдалд амь биеэ хайрлахгүй зүтгэх ажиллахын байдал.

ГҮЖИРЧ гүтгэх гүжирдэх заншилтай хүн, гөрч ч гэнэ; **гөрч гүжирч** х о р ш..

ГҮЖРЭХ: амин гүжрэх үйл ажилд амь тавьж ажиллах; *ажилд амин гүжрэхээс буцахгүй ажилладаг хүн.*

ГҮЗЭЭ 1. хэвэгч амьтны идсэн юмыг агуулдаг сав; **гэдэс гүзээ** х о р ш.; *хонины гүзээ; үхрийн гүзээ;* 2. гүзээнд хийсэн юм; *гүзээ тос; гүзээ сүү.*

ГҮЗЭЭЛЗГЭНЭ цэцэгт намхан ургамлаас гардаг ягаавтар улаан өнгөтэй маш амтлаг жимсгэнэ.

ГҮЗЭЭЛҮҮЛЭХ гүзээлэхийн үйлдүүлэх хэв.

ГҮЗЭЭЛЭХ 1. гүзээнд юм агуулах; 2. амьтны гэдэс хэвэл таргалах.

ГҮЙВҮҮР дүүгүүр.

ГҮЙВҮҮРДЭХ дүүгүүрдэх.

ГҮЙВЭР тариа будааны иш үрийг жанчин салгах хэрэглэл, түншүүр ч гэнэ, лэнгэ ч гэнэ.

ГҮЙВЭРДЭХ 1. тариа будааг гүйврээр цохиж иш үрийг салгах; 2. аливаа хэрэглэж болохгүй юмыг гээх уурах.

ГҮЙДЭЛ гүйх үйлийн нэр; 1. гүйх явдал; *моринь гүйдэл;* 2. ан амьтны явах зорчих зам; *чоно гүйдэл; бугын гүйдэл;* **цахилгаан гүйдэл** (дамжуулагчаар цахилгаан цэнэгийн гүйх хөдөлгөөн); **цусны гүйдэл** (цусны урсгалын явц); ☆ **гүйдэл дайрах** х у у ч и р с а н (гариг өвчин тусах).

ГҮЙЛГЭНҮҮЛЭХ гүйлгэнэхийн үйлдүүлэх хэв.

ГҮЙЛГЭНЭХ юмны өнгө буюу гадаад талаар шингэн зүйл бий болон бүрхэсхийх; *нулимс гүйлгэнэх ус гүйлгэнэх.*

ГҮЙЛГЭХ I гүйхийн үйлдүүлэх хэв, гүйхэд хүргүүлэх; *гүйлгэн явах; тугалга гүйлгэх; бараа гүйлгэх; гүйлгэн бичих*

ГҮЙЛГЭХ II шөнийн цагт элбэнх мангисан зэрэгт нохой тавьж үнэрлүүлэн гөрөөчлөх; *нохой гүйлгэх.*

ГҮЙЛГЭХ III уруу суулгах; чацга гүйлгэх; *гэдэс гүйлгэх; уруу гүйлгэх.*

ГҮЙЛГЭХ IV дам дамжуулах; *түйпуу гүйлгэх; судар гүйлгэх; зоос гүйлгэх; цахилгаан гүйлгэх.*

ГҮЙЛГЭЭ худалдах юмыг арилжин дамжуулах явц; *гүйлгээ сайтай эд; гүйлгээгүй бараа; худалдаа гүйлгээ; бараа гүйлгээ.*

ГҮЙЛГЭЭЛЭХ худалдаа хийж явах.

ГҮЙЛГЭЭТЭЙ 1. гүйлгээ сайтай; *гүйлгээтэй бараа;* 2. зай самбаа ихтэй; *гүйлгээтэй хүн.*

ГҮЙЛНЭЙ у р г а м а л навч иш улны модонд адил, жимс улнаас бяцхан, амт гүйлсийн амттай ойролцоо нэгэн зүйл жимс.

ГҮЙЛС у р г а м а л модонд ургадаг, лис мэт их, өнгө шаравтар буюу улаавтар, амт хүчтэйхэн жимс, цэцэг цагаавтархан улаан, зүйл маш олон; **гүйлсэн шар** (улбар шараас баахан цайвархан шар өнгө).

ГҮЙЛТ гүйх үйлийн нэр; *гүйлт сайн; холын гүйлт.*

ГҮЙМТГИЙ гүймхий.

ГҮЙМХИЙ I ижлээ буюу нутгаа санаж гүйдэг мал; *гүймхий зээрд; гүймхий борлог.*

ГҮЙМХИЙ II амьтны дур урамшил ихтэй; *гүймхий бух; гүймхий нохой.*

ГҮЙН 1. мөхөс дутмаг; *санаа бодлого гүйн мөчид; эрдэм сурлага дутмаг гүйн;* гүйхэн ч гэнэ; 2. гүен; *гүйн ус.*

ГҮЙХ I 1. амьтны түргэвчлэн харайн явах; *гүйн ирэх; гүйн явах; уралдан гүйх; хорхой гүйх;* 2.морь малын ажил буюу нутгаа мөрөөдөж зорчин явах; *ардаг хүрэн Алтай нутагтаа гүйв; алиа саарал адуун сүрэгтээ гүйж харив;* 3. хөнгөн гавшгай хөдлөх; *тэр гуай гүйж харайсан сүрхий хөнгөн хүн;* 4. зарцлагдах; *б. буудын өмнө хойно гүйж амиа тэжээж явлаа.*

ГҮЙХ II зарим юмны түгэх нялзах, наалдах; *тугалга гүйх; паалан гүйх; гагнуур гүйх.*

ГҮЙХ III худалдах юмны хувилж борлох; *худалдаа гүйх; наймаа гүйх; бараа гүйх;*

ГҮЙХ IV эр хүйст амьтны от орох; *бух гүйх; нохой гичийд гүйх.*

ГҮЙХ V зарим юмны дамжих шилжих; *цус гүйх; цахилгаан гүйх; сампингийн эрх гүйх; ус гүйх; хаван гүйх;*

ГҮЙХЭН 1. чадвар дадлага сул дорой; *эрдэм сурлага гүйхэн; ажлын чадвар гүйхэн;* 2. гүехэн; *гүйхэн устай гол.*

ГҮЙЦДЭХ гүйцэд болох.

ГҮЙЦҮҮЛЭХ гүйцэхийн үйлдүүлэх хэв, гүйцэхэд хүргүүлэх.

ГҮЙЦЭГДЭХ 1. гүйцэхийн үйлдэгдэх хэв; *зугадаад гүйцэгдэв; хөөцөлдөөд гүйцэгдэв;* 2. мохол доройтолд хүрэх; *үнэнд гүйцэгдэх; зовлонд гүйцэгдэх.*

ГҮЙЦЭД дутуу дулимгүй бүрэн төгс; *бүрэн гүйцэд болжээ; гүйцэд мэдсэн.*

ГҮЙЦЭЛДҮҮЛЭХ гүйцэлдэхийн үйлдүүлэх хэв, бүртгэн нийлүүлэх, гүйцэтгүүлэх.

ГҮЙЦЭЛДЭХ гүйцэд болох, бүрдэх, бүрэн болох; *миний хэрэглэх зүйл гүйцэлдэв; ажил гүйцэлдэж байна.*

ГҮЙЦЭТГҮҮЛЭХ гүйцэтгэхийн үйлдүүлэх хэв.

ГҮЙЦЭТГЭГЧ ямар нэгэн ажил хэргийг ёсчлон биелүүлэх үүрэг хүлээсэн хүний албан тушаалын нэр.

ГҮЙЦЭТГЭЛ гүйцэтгэсэн нь; *гүйцэтгэл нь бага байна; гүйцэтгэлийн шалгалт хийх; гүйцэтгэлий нь дүгнэх.*

ГҮЙЦЭТГЭМ гүйцэтгэж болмоор, чадмаар.

ГҮЙЦЭТГЭХ гүйцэд болгох, биелүүлэх; *гүйцэтгэх үүрэг; гүйцэтгэх хүн; гүйцэтгэх газар; гүйцэтгэх чадвар.*

ГҮЙЦЭТГЭШГҮЙ гүйцэтгэж чадашгүй, болшгүй; *гүйцэтгэшгүй хэрэг тохиолдов;*

ГҮЙЦЭХ 1. зорьсон хүссэн үйл явдал хангагдах; *санаа гүйцэх; хүсэл гүйцэх;* 2. юм төгсөх; дуусах, барагдах, *хийж гүйцэх; хэрэглэж гүйцэх; хугацаа гүйцэх;* 3. юмны хүрэлцэх бүрдэх; *хэрэглэгдэхүүн гүйцэх; хэмжээ гүйцэх; нас гүйцэх; шүд гүйцэх;* 4. юмыг хөөн зэрэгцэх; *нэхэн гүйцэх; хөөн гүйцэх гүйцэж очих; гүйцээд түрүүлэх.*

ГҮЙЦЭЭГҮЙ гүйцсэнгүй, хүрсэнгүй, дуусангүй; *бичиж гүйцээгүй; идэж гүйцээгүй; сананд гүйцээгүй; хийж гүйцээгүй.*

ГҮЙЦЭЭЛГЭХ гүйцээхийн үйлдүүлэх хэв.

ГҮЙЦЭЭХ гүйцэхийн үйлдүүлэх хэв, гүйцэд болгох, дутагдалгүй бүрэн болгох: *гүйцээж бичнэ; ажлаа гүйцээж байж явна; түргэн гүйцээх хэрэгтэй.*

ГҮЛ ургамал шүүсэрхэг, анхилам үнэртэй, өнгө улбар шар, зөөлөн бөгөөд бэржгэрдүү арьстай нэг зүйл жимс.

ГҮЛДГЭР амьтны хүзүү хэвийн хэмжээнээс өлгөрдүү; *гүлдгэр хүзүүтэй.*

ГҮЛДИЙЛГЭХ гүлдийхийн үйлдүүлэх хэв.

ГҮЛДИЙХ гүлдгэр болох; *оготно залгисан могой шиг гүлдийж харагдах.*

ГҮЛДЭГНЭХ гүлдгэр юмны үргэлжлэн гүлдгэ гүлдгэ хийх.

ГҮЛДЭЛЗЭХ гүлдгэр юмны байн байн гүлдэс гүлдэс хийх.

ГҮЛС ургамал өнгө цагаан, хүйс том, ховонгийн адил, хавар цэцэглэх нэгэн зүйл цэцэг.

ГҮМ чимээ аниргүй нам жим, нам тайван; **нам гүм** хорш.

ГҮМБАРАА: гүмбараа матар амьтан хэлбэр гүрвэл мэт бөгөөд том, халуун орны гол мөрөн, нуур, намагт оршино; ихэнх гүмбараагийн биенийн урт нь 2—5 метр, заримын урт нь 10 метр ч хүрнэ, хөл нь богино бөгөөд бүдүүн, ам нь том, шүд хурц болоод олон.

ГҮН I Манж чин улсын хэтэрхий дөрвөн хэргэмийн дөрөвдүгээр; дотроо: улсын түшээ гүн, улсад туслагч гүн, гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж гэж гурван зэрэг байжээ.

ГҮН II хуучирсан гавьяа шагнал гэсэнтэй адил утгатай; *гүн байгуулав; гүн бий.*

ГҮН III ашигт малтмалын уурхай; *алтны гүн; нүүрсний гүн.*

ГҮН IV цэцэг өвчний туурлын уг авд арилахгүй яртсан нь; *цэцгийн гүн тогтох.*

ГҮН V 1. нягт их; *гүн ой; гүн шугуй;* 2. гүнзгий, лав; *гүн ус; гүн жалга; гүн шуудуу;* 3. юмны дотор лав орсон; *ойн гүн; арлын гүн; ажлын гүнд орж ажиллах хэрэгтэй;* 4. юмны дорхи; *газрын гүний ус; гүний муж; гүний чулуулаг; гүнийн хурдас.*

ГҮН VI өтгөн тод өнгө зүстэй; *гүн улаан; гүн ногоон; гүн шар; гүн харанхуй.*

ГҮН VII утга санаа нууц далд, ойлгоход бэрх; *гүн утга; гүн бодлого;* **гурван гүн** (их далайн ёроол гүн, эрдэмт хүний санаа гүн, энх төрийн бодлого гүн); **гүн ухаан** (нийгэм, байгаль, сэтгэхүйн хөгжлийн ерөнхий зүй тогтоол, хуулийг судлах ухаан); **гүн ухааны** (гүн ухаанд мэрэгжсэн хүн): **гүн ухаантан** (гүн ухаанд мэрэгжигсэд).

ГҮН VIII маш нарийн сайн хийцтэй; *гүн хийцтэй хэт хутга; гүн урлал.*

ГҮН IX хурцлаг сайн амт; *гүн амттай хоол; гүн шөл.*

ГҮНГЭНҮҮЛЭХ гүнгэнэхийн үйлдүүлэх хэв.

ГҮНГЭНЭХ бусдад дуулдахгүй аман дотроо дуугарах; *гүнгэнэж униих; гүнгэнэж ярих.*

ГҮНГЭР: гүнгэр гангар хийх хүний харилцан хоорондоо дотно байдалтай сул үг хэлэлцэх; *хүүхэдтэйгээ гүнгэр гангар хийж сууна;* **гүнгэр гүнгэр хийх** (хүний бүдэг бүгт дуугарах);

ГҮНГЭРВАА зарим юм агуулах сав; *бүхны гүнгэрваа; зургийн гүнгэрваа.*

ГҮНД ургамал модонд ургана; сарны гэрэл туссан хойно нээгддэг дун цагаан өнгөтэй нэгэн зүйл цэцэг.

ГҮНДИЙ харагчин тотийн нэр.

ГҮНДҮҮГҮЙ 1. үнэнч шудрага, төлөв томоотой; *гүндүүгүй хүн;* 2. бядуу донгио, адарга зан байхгүй; *гүндүүгүй амьтан.*

ГҮНДЭЭХҮН хуучирсан таван эгшгийн нэр.

ГҮНЖ I сал.

ГҮНЖ II хаан хүний төрсөн охин.

ГҮНЖИД ургамал халуун оронд ургадаг нэг наст тосорхог ургамал дэл ч гэдэг; **гүнждийн тос** (гүнждээс ялгаруулан авсан тос).

ГҮНЗГИЙ гүн; *оломгүй гүнзгий ус; үгэа гүнзгий зохиол.*

ГҮНЗГИЙВТЭР баахан гүнзгий, арай гүнзгий.

ГҮНЗГИЙДҮҮЛЭХ гүнзгийдэхийн үйлдүүлэх хэв.

ГҮНЗГИЙДЭХ хэтэрхий гүнзгий болох.

ГҮНЗГИЙЛҮҮЛЭХ гүнзгийлэхийн үйлдүүлэх хэв.

ГҮНЗГИЙЛЭХ юмыг гүнзгий болгох; *худаг гүнзгийлэх.*

ГҮНЗГИЙРҮҮЛЭХ гүнзгийрэхийн үйлдүүлэх хэв, лавшруулах, ахиулах.

ГҮНЗГИЙРЭХ гүнзгий болох, лавшрах.

ГҮНЧҮҮ нимгэн сиймхий, нэгэн зүйл торгомсог барааны нэр.

ГҮНЭЭ лавтайяа, даамай; *гүнээ мэдэх; гүнээ болгоомжлох; гүнээ итгэх.*

ГҮР төмрийн хүдэр.

ГҮРВАА ургамал хулсан модны навчтай адилхан навчтай, ишийн үр тутам гурваад салаалж салаанаас найлзуур ургана, хүйс бяцхан нэгэн зүйл цэцэг.

ГҮРВЭЛ амьтан уртавтар сүүлтэй, нарийн уртлаг биетэй, эвэрлэг хальстай, дөрвөн хөлтэй жижиг амьтан; *хонин гүрвэл; могой гүрвэл.*

ГҮРВЭЛЗҮҮЛЭХ гүрвэлзэхийн үйлдүүлэх хэв.

ГҮРВЭЛЗЭХ гүрвэгэр юмны байн байн гүрвэс гүрвэс хийх.

ГҮРГЭМ халуун оронд ургадаг улбар шар өнгөтэй ургамал, эмнэлэгт хэрэглэнэ; *хач гүргэм; зом гүргэм; өвсөн гүргэм.*

ГҮРГЭР I товойж гудийсэн юм; *гүргэр судас; гүргэр ором.*

ГҮРГЭР II амьтан янз үхэртэй адилхан, өнгө харавтархан, нялх хүүхдийн дууны адил дуутай нэгэн зүйл амьтан.

ГҮРИЙХ гүргэр болох; *шанааны судас нь гүрийж харагдана.*

ГҮРЭВГЭНҮҮЛЭХ гүрэвгэнэхийн үйлдүүлэх хэв.

ГҮРЭВГЭНЭХ 1. гүрэвгэр юмны үргэлжлэн гүрвэг гурвэг хийх; 2. гүвнэх цөвтнөх.

ГҮРЭВГЭР гүргэр гүдгэр юм.

ГҮРЭЛЗГЭНЭ амьтан өнгө бараан, хоёр сүүлтэй, сахал жигүүр бий, зуны сүүлээр жигүүрээ хөдөлгөн дуугарна, тэжээж хэрэлдүүлэн наадах шувуу; *гүрэлзгэнэ зодолдуулах.*

ГҮРЭЛЗҮҮЛЭХ гүрэлзэхийн үйлдүүлэх хэв.

ГҮРЭЛЗЭХ гүргэр юмны байн байн гүрс гүрс хөдлөх; *судас гүрэлзэх; могой гүрэлзэх.*

ГҮРЭМ шашны ёсны зан үйл; *гүрэм ном хийлгэх;* **гүрэм дором** хорш..

ГҮРЭМДЭХ гүрэм хийх.

ГҮРЭМЧ гүрэм хийдэг хүн.

ГҮРЭН улс; **улс гүрэн** хорш.; *их гүрэн; бага гүрэн.*

ГҮРЭЭ хоолойн хажуугийн хоёр талыг дагаж байдаг бүдүүн судал ба түүний орчин газар; *гүрээний судас.*

ГҮТГҮҮЛЭХ 1. гүтгэхийн үйлдүүлэх хэв; 2. гүтгэгдэх; 3. зориуд хэтрүүлэх; *би түүнийг арай гүтгүүлэв.*

ГҮТГЭГДЭЛ гүтгэгдсэн нь.

ГҮТГЭГДЭХ гүтгэхийн үйлдэгдэх хэв.

ГҮТГЭЛЭГ гүтгэх нь; *гүтгэлэг хийх.*

ГҮТГЭХ оргүй хэргийг зохиож муутган унагах, худал хэрэг тулгах буюу гөрлөх; **гүтгэх гүжирдэх** хорш.: *зүй бусаар гүтгэж хэрэгт оруулав.*

ГҮТГЭЭЧ гүтгэх зантай, гөрч.

ГҮТЭГ амьтан янз өтөгтэй адилхан, өнгө хар нэгэн зүйл араатан.

ГҮҮ адуу, луус, чихтэй, тахь зэргийн гурваас дээш настай эм хүйстэй нь; *гүүний унага;* **гүү барих** (айраг хийхээр унага уяж гүүгээ саах); **гүү тавих** (саахаа больж унагыг сул тавих); **гүү саах** (а. гүүг ивэлгэн сааж сүүг

авах; б. чулуу зэргийн юм сөөлжүүлэн шидэж барьж авах наадам); **гүүний зэл** (унага уях зэл); **гүүний сацал** (гүү барьсан өдөр сүүнээс сацаж өргөх ёсон); **гүүний сацлын сударᠭ** (гүүний сацал хийх үест унших судар): **гүүний саам** (гүүнээс саасан сүү); **гүүний хөх** у р г а м а л нохойн хуухтай адил зэллэн ургана, жижигхэн гуагийн адил болоод хоёр үзүүрт шуумгай үүтэй ногоо. ᠭᠦᠦ

ГҮҮР гол мөрөн, төмөр зам зэргийг нэвтрэн гарахад зориулан хийсэн барилга; *модон гүүр гүүрээр гарах; төмөр замын гүүр.* ᠭᠦᠦᠷ • ᠭᠦᠦᠷᠢ

ГҮҮРГИЙ хурга ишгийг ялгах ба барихад хэрэглэх аялга; *гүүргий гүүргий.* ᠭᠦᠦᠷᠭᠡ

ГҮҮРГИЙЛҮҮЛЭХ гүүргийлэхийн үйлдүүлэх хэв. ᠭᠦᠦᠷᠭᠡᠯᠡᠭᠦᠦᠯᠬᠦ

ГҮҮРГИЙЛЭХ I. хурга ишгийг хониноос ялгах ба барихад гүүргий гүүргий гэж дуугарах; 2. хүн амьтныг хаацайлах хоргоох; *хүүхдийг битгий гүүргийл!* ᠭᠦᠦᠷᠭᠡᠯᠡᠬᠦ

ГҮҮРҮҮЛЭХ гүүрэхийн үйлдүүлэх хэв. ᠭᠦᠦᠷᠦᠦᠯᠬᠦ

ГҮҮРЭГ хавцал, хонгил, эрэг жалга нэвтрэн гарахад зориулан тавьсан гүүр. ᠭᠦᠦᠷᠦᠭ

ГҮҮРЭХ мэдрэх, ухаарах; *үчры нь гүүрч мэдэв.* ᠭᠦᠦᠷᠦᠬᠦ

ГҮҮТЭХ юмыг санаандаа үхширүүлэхгүй орхиж чадах. ᠭᠦᠳᠦᠬᠦ

ГҮҮШ 1. сайн орчуулагч; *гүүш нарын орчуулга;* 2. бичиг үсэг сайн мэддэг, бичгийн хүн. ᠭᠦᠰᠢ • ᠭᠦᠴᠢ

ГҮҮШИН машин, тэрэг зэрэг юмны дугуйны эргэх голыг холбох, бэхлэх хэрэгсэл; *тэрэгний гүүшин.* ᠭᠦᠰᠢᠨ

ГҮЦ шингэн юм агуулах бяцхан сав; *шаазан гүц; төмөр гүц; цайны гүц.* ᠭᠦᠴᠡ

ГҮШ дүрваагийн төрлийн нарийн ширхэгтэй нэг зүйл өвс, өлзийт өвс ч гэдэг. ᠭᠦᠰ

ГЭВ I хүч нэмэгдүүлэх үг; *гэв гэнт; гэв гэгээн; гэв гийх.* ᠭᠡᠪ

ГЭВ II гэх гэдэг үгийн өнгөрсөн цагийн хэлбэр, бусад үгтэй нөхцөж хэрэглэгдэнэ; *мөн гэв; яв гэв; уз гэв.* ᠭᠡᠪᠡ • ᠭᠡᠪᠡᠢ

ГЭВГҮЙ шашны хурлын хуврагуудыг баримтлан захирах албан тушаал; *цогчин гэвгүй.* ᠭᠡᠪᠭᠦᠢ

ГЭВЧ гэх гэдэг үгийн дутагдах нөхцөл; *сайн гэвч саар бас бий; баталсан гэвч сэргийлэх хэрэгтэй.* ᠭᠡᠪᠴᠡ • ᠭᠡᠪᠴᠡᠶᠡ

ГЭВШ шажны ёсны таван ухааны талаар мэргэжсэн хүн. ᠭᠡᠪᠰᠢ

ГЭВЭЛ гэх гэдэг үйл үгийн болзох нөхцөл; *мах идье гэвэл малаа; мантуу идье гэвэл тариагаа.* ᠭᠡᠪᠡᠯ • ᠭᠡᠪᠡᠯᠡ • ᠭᠡᠪᠦᠯ ᠭᠡᠪᠡᠯᠡ

ГЭГДГЭР нуруу нь тэнийхгүй бөхтөр болсон нь; *гэгдгэр нуруутай хүн.* ᠭᠡᠭᠳᠭᠡᠷ

ГЭГДЭХ гэхийн үйлдэгдэх хэв. ᠭᠡᠭᠳᠡᠬᠦ • ᠭᠡᠭᠳᠡᠭᠡ

ГЭГТЭХ гүүтэх. ᠭᠡᠭᠳᠡᠬᠦ

ГЭГЧ гэх гэдэг үгийн үйлт нэрийн одоо цагийн хэлбэр; *аврага могой гэгчийг үзсэн үү? Жамц гэгчийнд очлоо.* ᠭᠡᠭᠴᠦ • ᠭᠡᠭᠴᠡ

ГЭГЭЛЗЭХ толгойгоо өчүүхэн өчүүхэн дохихийх. ᠭᠡᠭᠡᠯᠵᠡᠬᠦ

ГЭГЭС: гэгэс гэгэс хийх толгойгоо байн байн дохих. ᠭᠡᠭᠡᠰ

ГЭГЭСХИЙХ толгойгоо түр дохих. ᠭᠡᠭᠡᠰᠬᠡᠬᠦ

ГЭГЭХ толгойгоо өчүүхэн дохих; *толгой гэгэх;* **гэгэх дохих** х о р ш.. ᠭᠡᠭᠡᠬᠦ

ГЭГЭЭ (Н) гэрэл: **гэгээ гэрэл; гэрэл гэгээ** х о р ш . ; **гэгээ тасрах** (нар шингэж харанхуй болох): **гэгээ орох** (үүр тэмдгэрч гэгээ үзэгдэж эхлэх); **гэгээтэй тасалгаа** (гэрэл сайтай тасалгаа); **гэгээтэйд явах** (харанхуй болохоос өмнө явах); **гэгээ гаргах** (гэрэл гаргах, гэгээтэй болгох); **гэгээн завсар** (а. гэгээ орохын өмнөхөн үе; б. дэлхий агаар мандал нийлсэн завсар). ᠭᠡᠭᠡᠨ

ГЭГЭЭВТЭР гэрэлтэйвтэр, гэрэлтэйхэн. ᠭᠡᠭᠡᠭᠴᠡᠷ

ГЭГЭЭВЧ байшингийн цонх; **гэгээвчийн ялуу** (цонхны хөндлөн мод): **гэгээвчийн халхавч** (цонхыг халхлах юм); **гэгээвчийн янз** (цонхны гоёлго); **гэгээвчийн сараалж** (цонхыг торлосон юм). ᠭᠡᠭᠡᠭᠴᠡ

ГЭГЭЭН 1. гэгээ гэрэл; 2. гэрэлтэй; *гэгээн наран; гэгээн саран;* 3 наш; *гэгээн сэцэн; гэгээн тунгалаг; гэгээн тодорхой;* 4. шажны ёсны ном номлолд мэргэжиж алдаршсан хүнд олгох цол. ᠭᠡᠭᠡᠨ • ᠭᠡᠭᠡᠭᠡᠨ

ГЭГЭЭРҮҮЛЭХ гэгээрэхийн үйлдүүлэх хэв; 2. бүдүүлэг ёсноос хагацуулах, боловсруулах. ᠭᠡᠭᠡᠭᠡᠷᠦᠦᠯᠬᠦ

ГЭГЭЭРЭЛ гэгээрэх нь; *соёл гэгээрэл; сурталгэгээрэл; гэгээрэл боловсрол; соёл гэгээрлийн ажил; ардын гэгээрлийн систем.* ᠭᠡᠭᠡᠭᠡᠷᠡᠯ

ГЭГЭЭРЭХ 1. гэгээ орох, гийх, тодорхой болох; *үүр гэгээрэх; тэнгэр гэгээрэх;* 2. боловсрох; *гэгээрч боловсрох; гэгээрсэн хүн.* ᠭᠡᠭᠡᠭᠡᠷᠡᠬᠦ

ГЭД хүний толгойн ардахь ёвгор. ᠭᠡᠳ

ГЭДВЭЛЗЭХ I 1. бүрэг дорой хүний хулмаганан эмээх; 2. гэдэг гэдэг хийх. ᠭᠡᠳᠪᠡᠯᠵᠡᠬᠦ

ГЭДВЭЛЗЭХ II 1. байн байн гэдийх; 2. тавтарь тогтворгүй байдал гаргах.

ГЭДГЭР 1. юмны хэвийн жишээнээс гэдэргэн байдалтай; *гэдгэр толгой; гэдгэр хад;* 2. ш и л ж с э н ихэмсэг дээгүүр зантай; *нэг их гэдгэр амьтан ирэв.* 3. хойрго, хэвцэг.

ГЭДИЙЛГЭХ гэдийхийн үйлдүүлэх хэв.

ГЭДИЙХ 1. гэдгэр болох, гэдрэг болгох; 2. үйл ажилд урагшлахгүй хойш татгалзах, хэвцэглэх; *түүнийг аргадаж хэлсэн чинь харин бүр гэдийж орхив.*

ГЭДРЭГ ар тийшээ харах буюу явах; *гэдрэг харах; гэдрэг явах; гэдрэг хандах.*

ГЭДРЭГДҮҮЛЭХ гэдрэгдэхийн үйлдүүлэх хэв.

ГЭДРЭГДЭХ хэтэрхий гэдрэг болох.

ГЭДРЭГЛЭХ гэдрэг болох, зориуд хойш суух; *ажлаас гэдрэглэх хэрэггүй.*

ГЭДЭГ I гэх гэдэг үгийн байнга гүйцэтгэх хэлбэр; *энэ үулыг Богд уул гэдэг; Аюуш гэдэг хүнтэй уулзлаа; ном үргэлж унш гэдэг байв; заавал намайг гэдэг чинь юу вэ?*

ГЭДЭГ II: **гэдэг гэдэг хийх** гэдгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ГЭДЭГНҮҮЛЭХ гэдэгнэхийн үйлдүүлэх хэв.

ГЭДЭГНЭХ 1. гэдгэр юмны гэдэг гэдэг хийх; 2. гэдвэлзэх, дохилзох.

ГЭДЭЛ хүний чихний доод үзүүр.

ГЭДЭЛЗЭХ гэдгэр юмны гэдэс гэдэс хийх.

ГЭДЭН I хэгжүүн, гөжүүн зантай; *гэдэнгийн нь бүү хөдөлгө.*

ГЭДЭН II: **гэдэн годон** тогтворгүй хөнгөн, байр суурь муутай; *гэдэн годон хийх.*

ГЭДЭС хүн амьтны хэвэл; *нарийн гэдэс; будүүн гэдэс; өлөн гэдэс;* **гэдэс хэвэл** х о р ш.; **гэдэс дотор** (хүн амьтны гэдэс хэвлийн дотоод дахь зүйлүүд: **гэдэс дотор, гэдэс гүзээ** х о р ш).; **гэдэс базлах, гэдэс мушгилах** (дотор эвгүйтэж базлан өвдөх); **гэдэс хуржганах** (гэдэс дүүрч хур хур дуугарах); **гэдэс гаргах** (мал нядлах); **гэдэс өлсөх** (хоол идэхийг хүсэх): **гэдэс цайх** (цагаан идээнд ханах); **их гэдэстэй** (жирэмсэн); **гэдэсний хижиг** (дотрын халдварт өвчин); **гэдэс дүүрэн** (цатгалан); **гэдэс дүүрэх** (а. цадах; б. гэдсэнд хий эзлэх); **гэдэс гарах** (сайн цадах); **гэдэсний цагаан хорхой** (амьтны гэдсэнд үүсч бий болдог нялцгай шимэгч хорхой).

ГЭДЭСЖИХ гэдсээрээ таргалах.

ГЭДЭСЛЭХ 1. гэдэсжих; 2. жирэмслэх.

ГЭДЭСХИЙХ амьтны толгой түр гэдийх.

ГЭЖ гэх гэдэг үгийн зэрэгцэх нөхцөл; *мэдрэл чинь муудаж байна гэж хэлэв; нэгдлийн дарга Баатар гэж та юу?; утаатай болор гэж ямар чулуу вэ?*

ГЭЗГЭВЧ 1. хазаарын шилэвч; 2. дуулганы хойд сүүл.

ГЭЗЭГ I хүний толгойн тайрч танаагүй буюу урт ургуулсан үс; **үс гэзэг** х о р ш.; **гэзэг гөрөх** (гэзэг сүлжих); **гэзэг тавих** (үс гэзгээ ургуулах); **гэзэгний боолт** (гэзэгний үзүүрийн чимэг); **гэзэгний даруулга** (гэзгийг шилний тус газраар хавчих чимэг); **гэзэгний залгаа** (гэзгэнд залгах хиймэл үс); **тав гэзэг** (эрэгтэй хүмүүс, эмэгтэй хүүхдийн толгойн оройд үлдээж ургуулсан үс гэзэг): **гэзэг дарах** (юмны хойноос ойрхон бараадан хөөх).

ГЭЗЭГ II уул толгодын ар шил, *уулын гэзэг; хуагийн гэзэг.*

ГЭЗЭГДҮҮЛЭХ 1. гэзэгдэхийн үйлдүүлэх хэв; 2. гэзэгдэгдэх.

ГЭЗЭГДЭХ гэзэг үснээс барих татах.

ГЭЗЭГЛЭХ уулын гэзгээр явах; *уул гэзэглэх.*

ГЭЛДРҮҮЛЭХ гэлдрэхийн үйлдүүлэх хэв.

ГЭЛДРЭХ маш алгуур аажмаар алхан явах; *мориор гэлдрэн явлаа.*

ГЭЛДЭРХИЙЛЭХ 1. хүн амьтны маш аажмаар алхлан зорчих; 2. хүний хөл, дэм алдаж арай ядан явах.

ГЭЛМҮҮЛЭХ гэлмэхийн үйлдүүлэх хэв.

ГЭЛМЭГЭЛЗЭХ бага хүүхэд унтаж байгаад маш айж гэнт уйлах ба гэнэт сочин хөдлөх.

ГЭЛМЭХ гэнт сочин айх, балмагдах; *айж гэлмэх хэрэггүй;* хэлмэх ч гэдэг.

ГЭЛЭН буддын шажны ёсны нэгэн зүйл санваар; **гэлэн болох** (гэлэн сахил хүртэх).

ГЭЛЭНМАА буддын шажны ёсны эм гэлэн,

ГЭМ 1. ёс зүйгээс ангид хийсэн үйл явдал, түүний уршиг нөлөө; *гэм явааг үй, зам явна; гэм хийх; гэм гаргах; гэмээ хүлээх;* **гэм зэм** х о р ш.; 2. өвчин эмгэг; *зүрхний гэм; гэм олох;*

ГЭМГҮЙ 1. хор хөнөөлгүй, гэм зэмгүй, учир холбогдолгүй; *гэмгүй хүнийг яадаг юм?;* 2. мөрөөрөө, төлөв томоотой; *тэр чинь гэмгүй хүн;* 3. зүгээр; *гэмгүй ирэг, гэмгүй явбал явж л байг.*

ГЭМНЭГДЭХ алдаслах, ташаарах.

ГЭМНЭХ алдал осол болох, буруудах.

ГЭМТ гэм бий; *гэмт хүн гэлбэлзэх, дайрт морь шарвалзах; гэмт хэрэг; гэмт этгээд.*

ГЭМТЭЙ 1. гэм хор бүхий; 2. итгэшгүй, сэжигтэй, гэнэхэн, томоогүй; *түүнд итгэхэд гэмтэй.*

ГЭМТЭЛ гэмтэх үйлийн нэр; *гэмтэл тохиолдох; машины гэмтэл.*

ГЭМТЭН гэмт этгээд, хэрэгтэн; **хэрэгтэн гэмтэн** х о р ш.

ГЭМТЭХ 1. юмны эвдрэх, бэртэх, хэмхрэх; *гэмтэх эвдрэх; яс гэмтэх;* 2. гутах, муудах, гэм олох; *ногоо гэмтэх;* ☆ **ам гэмтэх** (хүүхдийн аман дотор бяржруу гарах өвчин).

ГЭМТЭЭХ гэмтэхийн үйлдүүлэх хэв.

ГЭМШГЭЛЭН эндэгдэл алдагдалд гомдон гэмшсэн сэтгэл.

ГЭМШИЛ гэмшгэлэн.

ГЭМШИХ гэмээ мэдэн ухамсарлах; *гэм нь урдаа, гэмшил нь хойноо; гэмших сэтгэл төрөх; буруугаа гэмших.*

ГЭМШҮҮЛЭХ гэмшихийн үйлдүүлэх хэв.

ГЭМЭРГЭН хуйсчуур, үсчимтгий ааш муутай.

ГЭНГЭНЭХ 1. гаслах, гангинах; 2. уйтгарлан гэнших.

ГЭНГЭРЭХ 1. юмыг мөрөөдөн, сэтгэл зовниж, хэвийг алдах; *сэтгэл гэнгэрэх;* 2. өлсч ундаасаж тэсвэрлэх аргагүйд хүрэх; *өлсч гэнгэрэх; дотор гэнгэрэх.*

ГЭНГЭХ газар газар хэсүүчлэн явж амьдрах; *гэнгэж амьдрах; гэнгэж явах.*

ГЭНДЛЭГ бусдад мэхлэгдэх, хууртагдах нь.

ГЭНДЛЭР гэндэхдээ маш хялбар.

ГЭНДҮҮ барс, ирвэсийн эр.

ГЭНДҮҮЛЭХ гэндэхийн үйлдүүлэх хэв.

ГЭНДЭЛ эндэл осол; **осол гэндэл** х о р ш..

ГЭНДЭХ эндэх, осолдох, алдах, буруудах; *санамсаргүй байж гэндэв; хуурташ гэндэх; гэндэх гэдэг гэнэнийх.*

ГЭНТ санамсаргүй атал хурамханд болох юм; *гэнт ирэв; гэнт тохиолдов; гэнт үзээд маш сандрав.*

ГЭНТЭД гэнт, сочмог, түргэн зуур.

ГЭНЭН I 1. хал хашир үзээгүй, осолдох эндэхдээ хялбархан; *хүүхэд болоод гэнэн байна;* 2. тэнэг, сэргэггүй.

ГЭНЭН II буддын шажны ёсны гэлэн, гэцэл сахил аваагүй лам, увш ч гэдэг.

ГЭНЭХЭН нилээд гэнэн.

ГЭР 1. хүний оршин суух орон сууц; **гэр орон; орон гэр** х о р ш.: *монгол гэр; эсгий гэр; илүү гэр; таван ханатай гэр; арван хоёр ханатай гэр;* **гэр бүл** (гэрийн доторхи хүмүүс); **гэр бүл болох** (эр эм болох); **гэр гэрлэх** (а. гэргий авах; б. гэр орноо сайн авч явах); **гэр зуур** (а. гэрийн хүмүүсийн дотор; б. гэрийн орчин тойрноос үл холдох): **гэр зовох** (хөрөнгө ядуурах); **гэр ядуу** (ядуу хоосон); **гэр баян** (чинээлэг); **хар гэр** (шороо гяндан); **гэрээс гарах** (хувраг болох): **гэрээс гарсны тэмдэг** (ламын үнэмлэх бичиг); **гэр бараа** (гэр хөрөнгө); **гэрийн буурь** (а. гэр барих газар; б. гэр барьж байсан газар): **улс гэр** (улс үндэстэн); **гэрийг засах** (улс гэрийг түвшинтгэн мандуулах); **гэрийн үеийн бичмэл** (гэрийн тэргүүлэгчийн удам уламжлалын тодорхойлолт); **гэрийн мухар сахих** (юм үзэж нүд тайлахгүй бөглүү битүү байх); **гэрийн хүн** (а. гэргий; б. байнга гэртээ байхаас өөр боломжгүй болсон хүн): **гэрийн хэрэглэл** (гэрийн дотор тавих хогшил): **гэрийн эзэн** (өрхийн тэргүүлэгч); **гэрийн тэжээвэр амьтан** (таван хушуу малаас бусад тэжээвэр амьтад); **гэрийн мод** (унь, хана, хаалга, тооно); **гэрийн хоймор** (гэрийн голомтоос хойших хэсэг): **гэрийн хүмүүжил** (эцэг эхийн сургамж); **гэрийн даалгавар** (хичээлийн гадуур гэртээ хийх ажил); **гэрийн ариун цэвэр** (гэр орондоо цэвэр цээрч байх шаардлага): **гэр барих** (а. гэр гэрлэх; б. өрх хөрөнгө тусгаарлах; в. гэр босгон байгуулах; г. даалуу зэрэг зарим тоглоомоор тоглоход хэн ахлах модтой нь дарж өөрийн болгох); ☆ **гэрийн уянгат мод** у р г а м а л (уянгат модны нэг зүйл); **гэрийн хошоонгор** у р г а м а л (хошоонгорын нэг зүйл): **гэрийн буга**

а м ь т а н (нэг зүйл тэжээвэр том хулгана, мах иднэ); **гэрийн тотиг а м ь т а н** (тотигийн нэг зүйл шувуу); **гэрийн шувуу** а м ь т а н (тахиа); 2. амьтны үр зулзага орших сав; *хурганы гэр; тугалын гэр;* 3. юмны гадуурхи хальс бүрээс буюу ангуулах сав; *хорхойн гэр; малгайн гэр; нүдний шилний гэр; бууны гэр.*

ГЭРГИЙ эхнэр, эр нөхөртэй эмэгтэйг хүндэтгэн ийнхүү нэрлэнэ; *гэргий авах.*

ГЭРГИЙТЭЙ гэргий бүхий, эхнэртэй.

ГЭРГИЙТЭН 1. гэргий бүхий хүмүүс; 2. лам биш.

ГЭРГҮЙ огт оронгүй; *орох гэргүй, оочих ягагүй.*

ГЭРДЭХ загас агнахад гэрэл тусгах; *загас гэрдэх.*

ГЭРЛҮҮЛЭХ гэрлэхийн үйлдүүлэх хэв.

ГЭРЛЭГСЭД эр эм бололцогсод.

ГЭРЛЭЛТ гэрлэх үйлийн нэр; *гэрлэлтээ бүртгүүлэх; гэрлэлтээ цуцлуулах; гэрлэлт салалт.*

ГЭРЛЭХ I юманд бүрээс бүрхүүл гэр хийх.

ГЭРЛЭХ II эр эм бололцох, өмч хөрөнгө тусгаарлах, гэр хөрөнгийг эзэмших; *гэр гэрлэх.*

ГЭРЛЭЭГҮЙ эхнэргүй, нөхөргүй.

ГЭРТЭЭ өөрийнхөө гэрт; *гэр гэртээ харих; гэртээ урих; ах гэртээ бий.*

ГЭРЧ хэрэг явдлыг тодорхойлон батлахад холбогдох ямар нэгэн баримт болох зүйл; *гэрчийн этгээд; гэрч тэмдэг; гэрч баримт; гэрээ гэрч; амьд хүчий гэрч болохоор үхсэн хүний дэр болсон дээр* х у у ч.

ГЭРЧИЛГЭЭ албан ёсны баримт тодорхойолт; *үндсэн захиргааны гэрчилгээ; төрөгсдийн гэрчилгээ; сургууль төгссөн гэрчилгээ.*

ГЭРЧЛҮҮЛЭХ гэрчлэхийн үйлдүүлэх хэв, гэрчлэн тэмдэглүүлэх; *гэрээ гэрчлүүлэх.*

ГЭРЧЛЭХ хэрэг явдлыг батлан тодорхойлох зэргээр гэрч болох.

ГЭРЭВЧ 1. бамбар гэрэл; 2. хэд хэдэн лаа асааж болох суурь тавиур; 3. цэцэглэг дэн гэрэл.

ГЭРЭВШИМТГИЙ гэрэвших зантай.

ГЭРЭВШИХ хүнийрхэх, бишүүрхэх; *хүүхэд гэрэвшээд ирэхгүй байна.*

ГЭРЭВШҮҮ гэрэвшимтгий.

ГЭРЭВШҮҮЛЭХ гэрэвшихийн үйлдүүлэх хэв.

ГЭРЭЛ орчин ертөнцийг нүдэнд сэрэгдүүлэх сацраг хүч; *нарны гэрэл; цонхны гэрэл; галын гэрэл; гэгээ гэрэл; улаан гэрэл;* **гэрэл сацрах** (гэрэл бадран түгэх); **гэрэл тусах** (ямар нэгэн юмны гэрэл: туяа юманд хүрэх); **цахилгаан гэрэл** (цахилгаан хүчээр асах гэрэл); **гэрэл борлуулах** (цахилгаан гэрлийг худалдах); **гэрэл авахуулах** (гэрэл үзүүлж үл болох юмыг гэрэлд цохнулах); **гэрлийн хугарал** (тархаж байгаа гэрэл юмаар нэвтрэн гарахдаа хугаран өөрчлөгдөх үзэгдэл); **гэрлийн ойлго** (тархаж буй гэрэл юманд тусч тулаад буцаж дээш ойх үзэгдэл); **гэрлийн хурд** (секундэд 300 мянган километр явах хурд); **гэрэл дохио** (өнгө өнгийн гэрэл асах, мөн гэрлийг унтрааж асаах зэргээр өгөх дохио); **рентген гэрэл** (тунгалаг бус зүйлд нэвтрэх чадалтай гэрэл; техник, эмнэлэг зэрэг зүйлд хэрэглэнэ); **гэрэлд харуулах** (рентгений гэрэлд биеэ харуулах); **гэрэл зураг** (а. гэрэлд эмзэг чанар бүхий тусгай хальсанд юмны дүрс хэлбэрийг буулгах зүй: б. мөнхүү аргаар буулган авсан зураг); **гэрэл зурагч** (гэрэл зураг авдаг мэрэгжлийн хүн); **гэрэл зургийн газар** (гэрэл зураг авах ажил эрхлэх байгууллага); **гэрэл чимэглэл** (цахилгаан чимэглэл).

ГЭРЭЛГҮЙ 1. өнгө жавхаагүй; *гэрэлгүй царайтай хүн;* 2. харанхуй, бүрэнхий, бүдэг; *гэрэлгүй газар.*

ГЭРЭЛДҮҮЛЭХ гэрэлдэхийн үйлдүүлэх хэв.

ГЭРЭЛДЭХ гэрэл барьж юм харах; *харанхуйдаад байвал гэрэлдэж байгаад эрж үз.*

ГЭРЭЛЛЭГ гэрлийн үзэгдэл, чанарыг судлах ухаан.

ГЭРЭЛТ гэрэл бүхий; *гэрэлт чулуу;* **гэрэлт цамхаг** (хөлөг онгоцны зам чигийг заахад зориулан босгосон гэрэл бүхий өндөр цамхаг); **гэрэлт чимэд** (нэг зүйл эрдэнийн чулуу); **гэрэлт хөшөө** (гавьяа дурсгалыг тэмдэглэн байгуулсан хөшөө): **гэрэлт мананцар** (гэрэлтэн байх мананцар); **гэрэлт мандал** (нарны гэрэлт давхрагаас тогтсон хийн мандлын доод давхрага).

ГЭРЭЛТҮҮЛЭГЧ 1. гэрэлтүүр; 2. гэрэлтүүлэх үүрэг бүхий хүн.

ГЭРЭЛТҮҮЛЭХ гэрэлтэхийн үйлдүүлэх хэв, гэрэл гарга[illegible] тусгах.

ГЭРЭЛТҮҮР гэрэл гаргадаг юм; *машины гэрэлтүүр; бамбар гэрэлтүүр.*

ГЭРЭЛТЭЙ 1. гилбэгнэм гялбалзах гэрэл бүхий юм; *гэрэлтэй газар;* 2. хүний овор шинж, өнгө зүс, жавхлантай сайхан; *гэрэлтэй царай.*

ГЭРЭЛТЭЛТ гэрэлтэх чадал; **одны гэрэлтэлт** (аливаа одны гэрэлтэх чадал нарны гэрлээс их буюу бага алин болохыг харьцуулсан хэмжээ).

ГЭРЭЛТЭХ 1. гэрэл гарах, гэрэлтэй болох; 2. юмны өнгө, гэрэл туяа, юмны цаанаас нэвтрэн үзэгдэх; *гэрэлтэж харагдах нимгэн эд.*

ГЭРЭЭ I 1. гэрч тэмдэг болох баталгаа баримт; *аман гэрээ; бичгийн гэрээ;* **гэрээ баталгаа** х о р ш.; *гэрээ байгуулах; гэрээ батлах; гэрээ хэлэлцээр; харилцан туслалцах гэрээ; хамтран ажиллах гэрээ;* 2. хоёрын хооронд батлах хүн; **гэрээ гэрч** х о р ш..

ГЭРЭЭ II гэгээ гэрэл: *гэрээ шарлах; үүрийн гэрээ; гэрээ барих.*

ГЭРЭЭ III: **гэрээ хацар** нүдний дорхи хоёр түгдгэр.

ГЭРЭЭДҮҮЛЭХ гэрээдэх I II-ын үйлдүүлэх хэв.

ГЭРЭЭДЭХ I гэрээ хэлэлцээр хийх; *мод хийлгэхээр гэрээдэх.*

ГЭРЭЭДЭХ II шөнө гэрэл гэгээ барьж загас барих; *загас гэрээдэх.*

ГЭРЭЭЛҮҮЛЭХ гэрээлэхийн үйлдүүлэх хэв.

ГЭРЭЭЛЭХ аливаа гэрээ хэлэлцээр тогтоох батлах, гэрээ хийх; *нүүрс гэрээлэх; мод гэрээлэх.*

ГЭРЭЭС 1. хүн үхэхийнхээ урьд захиж хэлсэн үг, захиа; *гэрээс үг; гэрээс захиа; гэрээс хийх;* 2. урьдах үеийн үеэс улиран хадгалагдсаар ирсэн эд юм; *гэрээс эд.*

ГЭРЭЭСЛҮҮЛЭХ гэрээслэхийн үйлдүүлэх хэв.

ГЭРЭЭСЛЭХ хүн үхэхийнхээ өмнө үлдээх үг захиагаа захих.

ГЭСГҮЙ гэвгүй.

ГЭСГҮҮН хөлдүү биш, гэсгэлүүн.

ГЭСГЭЛҮҮН хөлдөж царцаагүй, уян зөөлөн байгаа юм; *гэсгэлүүн газар; мах гэсгэлүүн.*

ГЭСГЭЛЭН гэсгэлүүн.

ГЭСГЭХ гэсгээх.

ГЭСГЭЭХ I гэсэх I-ийн үйлдүүлэх хэв; *хэрцгий зангий нь гэсгээх хэрэгтэй.*

ГЭСГЭЭХ II гэсэх II-ын үйлдүүлэх хэв; *мах гэсгээх; газар гэсгээх.*

ГЭСЭР I цэцгийн доторхи үс мэт юм; **цэцгийн гэсэр** (туурцаг).

ГЭСЭР II у р г а м а л ардын эмнэлэгт хэрэглэдэг үрс; **гурван гэсэр** (нага гэсэр, бүсви гэсэр, бадам гэсэр).

ГЭСЭХ I хашрах, залхах, номхрох, сайжрах; *гэсч залхах; гэсч номхрох; гэсч томоожих.*

ГЭСЭХ II хөлдсөн царцсан юмны уяран зөөлрөн эебээргүү болох; *газар гэсэх; мөс гэсэх; худаг гэсэх.*

ГЭТЛҮҮЛЭХ гэтлэхийн үйлдүүлэх хэв.

ГЭТЛЭХ ямар нэгэн учрал тохиол, аюул тотгороос гатлах, хагацах, давах, туулан гарах; *өвчнөөс гэтлэх; өрнөөс гэтлэх; ус гэтлэх.*

ГЭТҮҮЛЭХ гэтэхийн үйлдүүлэх хэв.

ГЭТҮҮР I зүүрсан гурилыг нарийлан жижигхэн хэрчиж хуруугаар нитгэрч хагас бөөрөнхийдүү хэлбэртэй болгосон гурил, мөн түүгээр хийсэн хоол.

ГЭТҮҮР II этүүр.

ГЭТҮҮРЧ гэтдэг отдог зантай хүн.

ГЭТЭГЧ гэтдэг зантай.

ГЭТЭЛ гэх гэдэг үйлийн угтах нөхцөл; *явах гэтэл бороо оролд хойшлов.*

ГЭТЭЛГЭХ гэтлэхийн үйлдүүлэх хэв, гэтлүүлэх.

ГЭТЭХ бусдад сэрэгдэхгүйгээр сэмээрхэн явах; *хулгай хийхээр гэтэх; гөрөөлөхөөр гэтэх;* **гэтэх отох** х о р ш..

ГЭТЭЭЧ гэтдэг.

ГЭХ гэ гэдэг дутмаг үйл үгийн одоо ирээдүй цагийн төлөв; *ажилд яв гэх хэрэгтэй; заримдаа болно гэх, заримдаа болохгүй гэх хаашаа хүн бэ?; асуугаад үзвэл юу гэх бол; чамайг яа гэх вэ дээ; нэгэнт тийм болсон бол одоо яая гэх вэ; нөхдөө дууд гээ; цаашаа яв гээ; ахыгаа дагаад дүү нь явах гэх нь зөв; гэх мэт; гэх зэрэг.*

ГЭХГЭР ихээр хэгжүүн байдалтай.

ГЭХДЭГЛЭХ хэгжүүн зан байдал гаргах.

ГЭХЭГНЭХ гэхгэр хүний үргэлжлэн гэхэн гэхэг хөдлөх, аашлах.

ГЭХЭЛЗЭХ гэхгэр хүний байн байн гэхэс гэхэс хөдлөх.

ГЭХЭСХИЙХ түр зуур гэхэх.

ГЭЧ у р г а м а л нэгэн зүйл үр, цэцэг шар, үр хар будааны хир, өнгө нь улаан хар цагаан шар цөм бий, их тослог бөгөөд халуун амттай, юнгар ч гэнэ.

ГЭШҮҮ 1. модны хатсан мөчир салаа; *гэшүү түүх;* 2. малын имийн угийн шадар байдаг бүдүүн сурвалж; *хурганы гэшүү;* 3. үйл хэргийн нарийн учир; *гэшүү бүртгэх; гэшүү бүрдсэн хэрэг.*

ГЭШҮҮНЭ у р г а м а л цууртай, шүүсэрхэг иштэй, том далбагар навчтай, бүдүүн үндэстэй, үндэсний өнгө шар, ардын эмнэлэгт хэрэглэдэг, цооргана ч гэдэг.

ГЭЭ оольд барнул болгож хийсэн иш; *оолийн гээ; гэм нь ольдоо ч бий, гээндээ ч бий.*

ГЭЭГДҮҮЛЭХ гээгдэхийн үйлдүүлэх хэв.

ГЭЭГДЭХ гээхийн үйлдүүлэх хэв, хаягдах, орхигдох.

ГЭЭГҮҮЛЭХ 1. гээхийн үйлдүүлэх хэв; 2. гээгдэх.

ГЭЭГЭЭ х у у ч и р с а н хаад ноёдын охин.

ГЭЭЛ юмыг агуулахгүй бүрмөсөн орхиж хаясан нь.

ГЭЭЛГЭХ гээхийн үйлдүүлэх хэв, гээхэд хүргүүлэх.

ГЭЭЛЭХ олон юм буюу олыг гээх.

ГЭЭХ 1. эд юмыг осолдон хаях, орхих; *тулхүүрээ гээх; үнэмлэхээ гээх;* 2. юмыг халах өөрчлөх, орхих; *муу зангаа гээх;* 3. хүүрийг оршуулах тахиглах; *хүүр гээх;* **цаас гээх** (булш дээр цаас шатаах).

ГЭЭЧ гэ гэдэг дутмаг үйл үгийн шаардан захирах хэлбэр; *ахыгаа ир гээч; дүүгээ унт гээч.*

ГЭЮҮРЭХ юманд гүнээ санааширч бодлого болох; *зовж гэюүрсний хэрэггүй, зоригоо чангал!*

ГЮН хүндийн хэмжээ, гучин жин буюу 18 килограмм.

ГЯЛААН: гялаан од том буюу гэрэл тод одон; *марлын гялаан; үүрийн гялаан.*

ГЯЛАВ: гялавхийх юмны гэрэл жирэвхийн үзэгдэх; *цахилгаан гялавхийх;* **гялав гялавхийх** (байн байн гялавхийх).

ГЯЛАЙЛАА санаа гүйцлээ, баярлалаа; *над тус болсонд чинь их гялайлаа.*

ГЯЛАЙЛГАХ гялайхын үйлдүүлэх хэв.

ГЯЛАЙН: гялайн цайн юмны ив илэрхий үзэгдэх байдал; улаан цайн.

ГЯЛАЙХ 1. гялгар юмны гялбаганан үзэгдэх; *гал гялайх; толь гялайх;* 2. эрэл хүсэл гүйцэлдэх буюу ашиг тус хүртсэндээ баясан бахархах; *хүсэл ханаж гялайв; тус хүртэж гялайв.*

ГЯЛАЛЗАХ 1. өнгөт юм нарны гэрэлд жирэлзэн гялтганан үзэгдэх; 2. эд юмны өнгө хээ сайхан үзэгдэх; 3. хүний золбоотой сэргэлэн, өнгө жавхаатай үзэгдэх; *гялалзаж явах; гялалзсан амжилт гаргах;* 4. усанд туссан нарны гэрэл өөр газар тусч гялбан жирвэлзэн хөдлөх.

ГЯЛАЛЗУУЛАХ гялалзахын үйлдүүлэх хэв.

ГЯЛБАА I хурц гэрлийн сацран тусах туяа.

ГЯЛБАА II эргэн тойрон соёоны адил олон хушуу гарган эмжээрлэсэн нэг зүйл далбаа.

ГЯЛБААЛАХ нарны ба цахилгааны хурц гэрэл ус толь мэт тунгалаг юманд гялбаж уламжлан бусад юманд гялбах.

ГЯЛБАЛЗАЛ: гялбалзал цэцэг у р г а м а л алгана мэт том, улбар шар өнгөтэй нэг зүйл цэцэг.

ГЯЛБАЛЗАХ 1. хурц гэрэл бүхий буюу гялгар өнгөт юмны гэрэл туяа, түүний гэрэл туссан юмны гялс гялс хийх; 2. хүний гавшгай золбоотой хөдлөх, аашлах.

ГЯЛБАЛЗУУЛАХ гялбалзахын үйлдүүлэх хэв.

ГЯЛБАЛЗУУР I амьтны гавшгай золбоотой хөдөлгөөний байдал; *гялбалзуур хүн.*

ГЯЛБАЛЗУУР II: **гялбалзуур цэцэг** у р г а м а л өндөр иштэй, ногоон навчтай, зун цэцэглэдэг нэгэн зүйл цэцэг.

ГЯЛБАРЛАГА нарны гялбаа ус толь мэтэд гялбаж уламжлан бусад юманд туссан гэрэл.

ГЯЛБАХ 1. хурц гэрэлд нүд халтирах зэргээр тавтайяа харж үл чадах; *нүд гялбах; наранд гялбах; галд гялбах; цасанд гялбах;* 2. нар гарч гэрэл гусах; *нар гялбах.*

ГЯЛБУУЛАХ гялбахын үйлдүүлэх хэв.

ГЯЛГАНА: гялгана загас а м ь т а н гол мөрөнд орших нэг зүйл жижиг загас, махыг иднэ.

ГЯЛГАР I юмны гялтганам өнгө; *гялгар алт; гялгар чулуу; гялгар шил;* **гялгар цалгар** х о р ш.

ГЯЛГАР II нэгэн зүйл сиймхий хадаг; *гялгар хадаг; гялгар вандан.*

ГЯЛДАА ёслолд хэрэглэх торгомсог эдээр хийсэн нэг зүйл унжлага чимэг.

ГЯЛС: гялс гялс хийх байн байн гялс хийх.

ГЯЛСХИЙЛГЭХ гялсхийхийн үйлдүүлэх хэв.

ГЯЛСХИЙХ 1. гэрэл бүхий юмны наранд түр жиргэлэх; *шил гялсхийх;* 2. юмны агшин зуур үзэгдэн өнгөрөх; *цахилгаан гялсхийх; оч гялсхийх; морьтой хүн гялсхийгээд өнгөрөв.*

ГЯЛТАЙХ гялтгар болох, гялтайн харагдах.

ГЯЛТАЛЗАХ гялтгар юмны гялтас гялтас хийх.

ГЯЛТАН: гялтан гялтан хийх гялтгар юмны гялтганан харагдах.

ГЯЛТГАНА шороо чулуулгийн зүйлд холилдож гялтгархан үзэгдэх гялгар юм.

ГЯЛТГАНАХ гялтгар юмны гялтга гялтга хийх.

ГЯЛТГАНУУЛАХ гялтганахын үйлдүүлэх хэв.

ГЯЛТГАНУУР өнгө гялгар, хуудсарсан нэг зүйл чулуулаг.

ГЯЛТГАР гялгар юм; *гялтгар шил; гялтгар чулуу.*

ГЯНДАН хэрэгтэн ялтан хүнийг хорихоор тусгай бэлтгэсэн газар; **шорон гяндан** х о р ш.

ГЯРХАЙ урьд үзсэнээ танихдаа чадамгай; *малд гярхай хүн; гярхай нохой; гярхай нүдтэй.*

ГЯРХАЙДАХ дэндүү гярхай болох.

ГЯРХАЙЛАХ гярхай байдал гаргах.

ГЯРХАЙРАХ гярхай болох.

ГЯРХАЙШИХ гярхай шинжтэй болох.

Д

Д 1 Д үсэг, Д авиа; 2. тавдахь, тавдугаар; *«Д»-д дурдсан нь.*

ДАА I 1. х у у ч и р с а н их; *даа хүрээ; даа дарга;* **даа лам** (шажны хурлын захиргааны хэрэг эрхэлсэн хүний тушаал); 2. дарга; *чуулган даа; даагийн жасаа.*

ДАА II батлах сул үгийн утга; *одоо амарч унт даа; чи энэ номыг ав даа.*

ДААВУУ 1. хөвөн бараа; *цоохор даавуу; шивуу даавуу;* 2. даавуугаар хийсэн эдлэл; *орны даавуу; гэрийн даавуу; даавуу цаваг; даавуу бээлий.*

ДААГА I хоёр настай адуу; *дааган дааган хар нь ташаандаа дарсан тамгатай* а р д ы н д у у; **даага сургах** (номгон болгох): **дааган тором** (хоёр настай тэмээ); **дааган чих** у р г а м а л чийгэрхэг хөвсгөр хөрстэй газар бут буюу бутархаг байдлаар ургана, нарийн урт улаавтар өнгийн навчтай, жижигхэн үртэй, гашуувтар исгэлэн амттай олон наст ургамал, төрөл зүйл олон.

ДААГА II тооны доторхи хөндлөн хэгээс мод; *тоононы даага;* 2. толгой талыг холбосон хоёр унь; *даага унь;* 3. хялгасаар холболдсон хоёр хомоол; **дааган хомоол** (үүнийг унага ихэрлэнэ гэж бэлгэдэл болгон ханын толгойноос өлгөх заншил байдаг).

ДААГАЛАХ 1. хоёр унийн толгой талыг холбох; 2. хүүхдийн маш дотнолон салалтгүй үерхэх; *манай хоёр хүүхэд унагалж даагалж явдаг юм.*

ДААГДАХ 1. даахын үйлдэгдэх хэв; 2. давагдах, дийлэгдэх.

ДААГЧ даасан этгээд; *батлан даагч*

ДААЖИГНАХ буцдыг басч доромжлон доог тоглоом хийж даажин болгох; чи *битгий даажигнаад бай!.*

ДААЖИГНУУЛАХ I. даажигнахын үйлдүүлэх хэв; 2. даажигнагдах.

ДААЖИН 1. тоглоом тохуу болгосон нь; 2. басч доог болгосон нь; *даажин хийх.*

ДААЛГАВАР гүйцэтгүүлэхээр өгсөн үүрэг; *даалгавар өх; даалгавар хийх; даалгавар авах; гэрийн даалгавар.*

ДААЛГАХ I даахын үйлдүүлэх хэв, даахад хүргүүлэх; *ажил даалгах.*

ДААЛГАХ II үйл ажлыг чамбай сайн хийх; *ажил хийхдээ даалгаж хийж сурах хэрэгтэй.*

ДААЛГУУЛАХ даалгахын үйлдүүлэх хэв.

ДААЛИГНАХ даалинд юм хум агуулах.

ДААЛИН 1. хувцас хунир зэргийг агуулах том богц сав; булигаар, хөм, зузаан бөс зэргээр хийнэ; 2. хөөрөг агуулах бөс торгомсог эдээр хийсэн жижиг сав; **хөөрөг даалин** х о р ш . .

ДААЛИНБА нэгэн зүйл хөвөн нэхмэл бараа; *даалинбан дээл; боодлын даалинба.*

ДААЛИНЖИН даалинба.

ДААЛИУ даалуу.

ДААЛТ даан батлах хүн; *даалтаар суллагдах.*

ДААЛУУ 1. 2-оос 12 нүх гаргасан 60 тооны жижиг дөрвөлжин яс буюу модоор хийсэн тоглоом; *даалуу тавих; даалуугаар гэр барих;* 2. мөн тоглоомын 12 нүхтэй мод; *даалуугаар идэх; даалуугаар гарах.*

ДААЛУУДАХ даалуу тавьж наадах.

ДААЛУУЧ даалуугаар наадахад чадамгай хүн.

ДААМ 1. шатрын хөлөг дээр цагаан хараар тэмцэн тоглох тоглоом; *даам тавих; даам нүүх;* 2. даамаар тоглоход нөгөө этгээдийн захад хүрч чадсан учраас хол алгасан нүүх эрхтэй болсон хүү; *даам гарах; миний даам.*

ДААМАЙ хуумгай биш, даацтай, чамбай, ул суурь сайтай; *түргэн түүхий, удаан даамай* з ү й р .

ДААМАЛ ямар нэгэн газрыг толгойлсон хүн; *сургуулийн даамал; агтны даамал; жасын даамал.*

ДААМГАЙ 1. юмыг чамбай сайн хийдэг хүн; 2. даахдаа сайн; *даамгай ат;* 3. тэсвэртэй; *хүйтэнд даамгай; өл хоол даамгай.*

ДААМДАХ даамаар тоглох, даам тавих; *хоёул даамдах уу?.*

ДААМЖРАХ цаашид удаандаа улам лавшрах; *өвчин нь даамжрах; үл бүтэх ажил нь даамжрах.*

ДААМЖРУУЛАХ даамжрахын үйлдүүлэх хэв, даамжрахад хүргүүлэх.

ДААМТГАЙ даамгай.

ДААН хэтэрхий, дэндүү, тун, огоо, нэн, дандаа; *даан дэндүү байсан юм!; даан их хөөрөөд байсан; даан болохгүй хэрэг; даан цөөхөн; даан тэгж сурсан хүн.*

ДААНЧ даан, дэндүү, хэт; *даанч даа! даанч яав даа! даанч тэгэхгүй биз!*

ДААПАА даажин, тохуу.

ДААПААЛАХ даапаа хийх, тохуу хийх; *битгий даапаалаад бай!.*

ДААРАХ хүйтэнд бие хөрөх; *даарах хөрөхийг үл мэдэх;* **яарвал даарна** з ү й р .

ДААРДАС бие живрэх, жихүүцэх; *даардас хүрэх.*

ДААРУУЛАХ даарахын үйлдүүлэх хэв.

ДААТГАЛ даатгах үйлийн нэр; **нийгмийн даатгал** (ажилчин албан хаагчдын хөгшрөх, өвдөх, хөдөлмөрийн чадвараа алдах зэрэгт материалын тусламж үзүүлэх арга хэмжээний систем); *амь даатгал; даатгалын татвар; даатгал хийх*

ДААТГАХ 1. хувь заяагаа бусдад итгэж хариуцуулах; 2. тусгай хууль дүрмийн ёсоор албан байгууллагад татвар төлж амь бие, эд хөрөнгөө хамгаалуулах; *амь биеэ даатгах; эд хөрөнгөө даатгах.*

ДААТГУУЛАХ даатгахын үйлдүүлэх хэв.

ДААХ I 1. юмыг өөд нь өргөж чадах; дээрээс нь тавих, ачихад тэсвэрлэн тогтоох; *өрөөсөн гараараа даах; үүрээд явсан нь даахаа болив; хүнд ачааг даах тэрэг;* 2. ш и л ж с э н тэсвэрлэх, давах; *хүйтэн даах; тэмээ өл даахдаа сайн; өвчин даах; тоглоом даах; ус даах; бороо даахдаа сайн цув.*

ДААХ II огтолж, зүсч ,хазаж чадах; *юм даадаггүй хутга; юуг ч даах сайн шүдтэй.*

ДААХ III батлах, хариуцах; *намын гишүүнд элсэхэд даах хүн хэрэгтэй болжээ; сайн болгохыг би батлан даая; даана гэж өгөхийн нэр, далайна гэж цохихын нэр* з ү й р; **даан авах** (аливаа үйл явдлыг бнедээ хүлээж хариуцан авах).

ДААХ IV дааварлах, нэвтрэх нэвчих; **тос даасан** (тос нэвтэрсэн); *чийг даах.*

ДААХИРАХ ус ширэлдэх, ороцолдон барилдах; *гэзэг даахирах; морины сүүл даахирах.*

ДААХИРУУЛАХ даахирахын үйлдүүлэх хэв.

ДААХЬ 1. ширэлдсэн ус хялгас; *дахан дор эр, даахин дор хүлэг* з ү й р; 2. хүүхдийн нялхын ус; **даахь авах** (хүүхдийн нялхын үсийг авах); **даахь гаргах** (хүний гэзэгний ширэлдсэнийг самнан даахигүй болгох); **даахь халах, даахиа халах** (мал гөрөөсний хуучин хагд үсээ халах).

ДААЦ I 1. даах чадал; *хагас тонны даацтай тэрэг; галт тэрэгний даац;* 2. ш и л ж с э н хянамгай, нягт, чамбай, гүйцэд; *ажлыг даацтай хийдэг хүн.*

ДААЦ II огтлох зүсэх чадал; *даацтай хайч; даацтай хөрөө.*

ДААЦ III угийн балчиг шавартай газар.

ДААЦЛАХ газрын дороос ус нэвчиж дээш нэвтрэн гарах.

ДААЧАА ачаа тээх морин тэрэг; *даачаа тэрэг.*

ДААШИН татлагын бүдүүн олс.

ДААШИНЗ нимгэн эдээр хийсэн дан дээл.

ДААЯА гаанс, тамхи.

ДАВ I: **дав дув хийх, дав дав хийх, дав хийх** 1. бие гэнт агзасхийн хөдлөх; *сочсоноос болж бие дав дув хийв;* 2. сочмог түргэн хөдлөх; *дав хийн босов;* 3. түргэн дөхмийг бодох; *дав дувыг бодох; давыг бодож би хийчихье.*

ДАВ II: **дав дээр** одоо дээр, одоохондоо, даруйдаа, урдаар; *дав дээр хийх ажил; дав дээр уншиж сурах хэрэгтэй;* **давын өмнө** (юуны өмнө, юуны урьд; *давын өмнө үүнийг хийх хэрэгтэй).*

ДАВ III **дав ч үгүй** тоомсорлохгүй, сочоогүй, жишимгүй; *хэлээд байхад дав ч үгүй суудаг чинь юу вэ?*

ДАВ IV: **дав даваар** зэрэг зэргээр; *дав даваар ирцгээв.*

ДАВАА I уулыг давах замтай газар; **даваа давах** (а. даваан дээгүүр өнгөрөх; *Эгийн даваа давах;* б. хүнд хүчир үйл явдлыг туулж өнгөрөх, дийлэх; *цэцэг өвчний даваа давах).*

ДАВАА II бэрхшээл төвөг, хэцүү бэрх; *энэ ч харин даваатай хэрэг байна; амаргүй даваа шив дээ.*

ДАВАА III **бөхийн** барилдах үе; *нэгийн даваа дуусав; тавын даваанд унав.*

ДАВАА IV долоон хоногийн нэгдэх өдөр.

ДАВАА V нарны аймгийн нэг ертөнц.

ДАВААДАХ хэцүүдэх, бэрхдэх, хирээс хэтрэх үйл ажилд их л ядаж зүдэх; *шалгуулах гэж даваадлаа шүү; алдсан малаа эрж олох гэж даваадав.*

ДАВААДУУ 1. даваа ихтэй; 2. хирээс хэтрүү, ахдуу.

ДАВААДУУЛАХ 1. даваадахын үйлдүүлэх хэв; 2. хэтрүүлэх, цаашлуулах; *намайг битгий даваадуулаач.*

ДАВААТАЙ 1. давах даваа бүхий; 2. бэрхтэй, хэцүү; *хүйтэнд байнга явах ч даваатай байна шүү.*

ДАВАМГАЙ даврамгай, хирээс хэтрэмгий зантай; *хүнд давамгай зан хэрэггүй байдаг.*

ДАВАМГАЙЛАХ хирээс хэтэрхий авирлах, давамгай зан байдал гаргах

ДАВАХ I юмны дээгүүр зорчин өнгөрөх; *даваа давах; хашаан дээгүүр давах.*

ДАВАХ II хүнд бэрх юмыг туулж дээр нь гарах, төгсгөх, гүйцээх; *аюулыг давж өнгөрөв; өвчнийг давлаа; бид давах ажил.*

ДАВАХ III илүү гарах; *хориос давах тоотой хонь; төлөвлөгөө нь давж биелсэн байна.*

ДАВАХ IV ялах, дийлэх; *гурав давав; тав давсан бөх; хэл амаар давах; чадал хүчээр давах.*

ДАВАҲ V зөрчих, хэтрэх; *хууль давах; давж заалдах; хил давах; хязгаар давах.*

ДАВАХГҮЙ дийлэхгүй, зөрчихгүй, чадахгүй, хүч хүрэхгүй; *давахгүй дагадаг ард; давахгүй гэсэн даваагаар гурав дахин давах* з ү й р; *давахгүй ажил; арваас давахгүй тооны үхэр.*

ДАВГҮЙ ажрахгүй, тоохгүй; *худал хэлчихээд огт давгүй байв гэнэ; хол явсан хир нь ядраагүй, давгүй байна.*

ДАВЖАА өсөлт муутай, бие бага; *давжаа хурга; давжаа хүүхэд.*

ДАВЖААДАХ хэтэрхий давжаа болох; *даанч давжаадаад байна даа.*

ДАВЖААРАХ улам давжаа болох.

ДАВЖГАНАХ 1. хүйтэнд даарч тачаадтал чичрэх дагжих; *бие давжганах; шүд давжганах;* 2. давигнах, хавьчих.

ДАВЖИХ улмаар хүмүүжин өсч дэгжих, ᠳᠠᠪᠵᠢᠬᠤ

ДАВИГНАХ давигнуур хүний ярих; *давигнасан сүрхий яриатай хүн.* ᠳᠠᠪᠢᠭᠨᠠᠬᠤ

ДАВИГНУУР ам түргэнтэй, хамаагүй ярьдаг; *давигнуур хүн.* ᠳᠠᠪᠢᠭᠨᠤᠤᠷ

ДАВИРАА давирах зантай. ᠳᠠᠪᠢᠷᠠᠭ

ДАВИРАХ I 1. унасан малыг хөл буюу дөрөөгөөр дэлдэх; *морь давирах;* 2. халдан хавирах; *би давираад унагав;* 3. муутган дийлэх; *түүнийг энэ удаа давирсан шүү.* ᠳᠠᠪᠢᠷᠬᠤ

ДАВИРАХ II: **амь давирах** гацхүү амь хувиа хэтэрхий бодох. ᠳᠠᠪᠢᠷᠬᠤ

ДАВИРУУЛАХ 1. давирахын үйлдүүлэх хэв; 2. давирагдах. ᠳᠠᠪᠢᠷᠤᠤᠯᠬᠤ

ДАВИРХАЙ шилмүүст мод болон бусад зарим ургамлаас гарах наалдамхай, агаарт хатах шүүс, *шар давирхай; модны давирхай;* ☆ **давирхай шил** (хув). ᠳᠠᠪᠢᠷᠬᠠᠢ

ДАВИРХАЙДАХ 1. юманд давирхай түрхэх; 2. хэтэрхий давирхай болох. ᠳᠠᠪᠢᠷᠬᠠᠢᠳᠠᠬᠤ

ДАВИРХАЙЛАХ юмнаас давирхайгий нь авах, юмны давирхайгий нь арилгах; *мод давирхайлах.* ᠳᠠᠪᠢᠷᠬᠠᠢᠯᠠᠬᠤ

ДАВИРХАЙЛУУЛАХ давирхайлахын үйлдүүлэх хэв. ᠳᠠᠪᠢᠷᠬᠠᠢᠯᠤᠤᠯᠬᠤ

ДАВИРХАЙТАХ давирхайтай болох, давирхай гарах. ᠳᠠᠪᠢᠷᠬᠠᠢᠲᠠᠬᠤ

ДАВИЧИХ 1. байн байн давирах; *морио дандаа давичих хэрэг юун;* 2. хавьчих. давигнах, янших, хавьчиж *давичсан сүрхий эмгэн байв.* ᠳᠠᠪᠢᠴᠢᠬᠤ

ДАВЛАГАА (Н) усны их долгион; *далайн давлагаа.* ᠳᠠᠪᠯᠠᠭ

ДАВЛАГААЛАХ давлагаан гарах; *давлагаа лах үеэр далайд явахад бэрхтэй.* ᠳᠠᠪᠯᠠᠭᠠᠯᠠᠬᠤ

ДАВЛАХ 1. шингэн юм савнаасаа оргилон хальж бялхах; *тогоотой цай оргилон давлах;* 2. долгилох; давлагаалах; *тэнгэсийн ус давлан долгилж байна* ᠳᠠᠪᠯᠠᠬᠤ • ᠳᠠᠪᠯᠠᠬᠤ

ДАВЛУУЛАХ давлахын үйлдүүлэх хэв. ᠳᠠᠪᠯᠤᠤᠯᠬᠤ

ДАВРААХ даврахад хүрүүлэх, даврууулах. ᠳᠠᠪᠷᠠᠭᠬᠤ

ДАВРААЧ хэтэрхий давруу; *давраач зантай хүн.* ᠳᠠᠪᠷᠠᠴ

ДАВРАГА жижигхэн богц сав, шуумааз ч гэнэ. ᠳᠠᠪᠷᠠᠭ

ДАВРАМТГАЙ хэтэрхий даврах зантай. ᠳᠠᠪᠷᠠᠮᠲᠭᠠᠢ

ДАВРАМХАЙ хирээс хэтрэмтгий зан ааштай. ᠳᠠᠪᠷᠠᠮᠬᠠᠢ

ДАВРАХ хир хэмжээнээс хэтрэмтгийлэн аашлах, эрэмшин нэтрэх; *даварсаар даварсаар Дагвын өрөн дээр* з ү й р . ᠳᠠᠪᠷᠠᠬᠤ

ДАВРУУ хир хэмжээнээс хэтрүү зан ааштай. ᠳᠠᠪᠷᠤᠤ

ДАВРУУЛАХ даврахын үйлдүүлэх хэв. ᠳᠠᠪᠷᠤᠤᠯᠬᠤ

ДАВС 1. гашуундуу хурц амттай талст бодис, хоолонд амт оруулахад хэрэглэнэ; *хоолны давс; чулуун давс;* **давс хийвэл уустал, ажил хийвэл дуустал** (нэгэнт ажиллавал сайн ажилла); 2. устөрөгчийн атом нь төмөрлөгийн атомаар солигдсон химийн бодис; *бертолетийн давс; давсан хүчил.* ᠳᠠᠪᠰ

ДАВСАГ давсан. ᠳᠠᠪᠰᠠᠭ

ДАВСАН амьтны шээс хуралдах эрхтэн. ᠳᠠᠪᠰᠠᠨ

ДАВСАРХАГ давс ихтэй; *давсархаг цай.* ᠳᠠᠪᠰᠠᠷᠬᠠᠭ

ДАВСАРХУУ 1. давсархаг; 2. давстай төстэй, давс мэт. ᠳᠠᠪᠰᠠᠷᠬᠤ

ДАВСГҮЙ давс дутсан; *давсгүй хоол амтгүй.* ᠳᠠᠪᠰᠭᠦᠢ

ДАВСДАХ 1. давс түрхэх; 2. давс нь ихдэх. ᠳᠠᠪᠰᠳᠠᠬᠤ

ДАВСЛАГ давс нь ихэвтэр. ᠳᠠᠪᠰᠯᠠᠭ

ДАВСЛАХ 1. давстай болгох, давс ба давсны уусмалд хийж хадгалах, амт оруулах; *арьс нэхий давслах; ногоо давслах; мах давслах;* 2. юмны хүчийг нэмэгдүүлэх, хэтрүүлэх; *давсалж ярих; давсалж бичих; юмыг дандаа давсалж байдаг хачин хүн байна шүү чи.* ᠳᠠᠪᠰᠯᠠᠬᠤ

ДАВСЛУУЛАХ давслахын үйлдүүлэх хэв, давслахад хүрүүлэх. ᠳᠠᠪᠰᠯᠤᠤᠯᠬᠤ

ДАВСНАГ давсаг. ᠳᠠᠪᠰᠠᠭ

ДАВСРАХ давс мэт байдалтай болох; *хаврын мөс урт уртаар цуурч давсарчээ; цасны ширхэг хатуурч давсарсан байна.* ᠳᠠᠪᠰᠠᠷᠬᠤ

ДАВСТ давс бүхий юм; *давст нуур;* ᠳᠠᠪᠰᠲᠤ

ДАВСТАХ давс тогтох, бий болох. ᠳᠠᠪᠰᠲᠠᠬᠤ

ДАВСЧИН давс шүүгч, давс боловсруулагч; *давсчин хүн.* ᠳᠠᠪᠰᠴᠢᠨ

ДАВТАГДАХ I давтахын үйлдэгдэх хэв. ᠳᠠᠪᠲᠠᠭᠳᠠᠬᠤ

ДАВТАГДАХ II үйл ажилд нэрвэгдэх, дарагдах, дарлагдах.

ДАВТАН 1. давглага; *давтан сургах; давтан хичээл;* 2. дахин; *дахин давтан захив.* ᠳᠠᠪᠲᠠᠨ

ДАВТАХ 1. юмыг дэлдэж хавтгайлах, цохилхийлэх; *төмөр давтах; шороо давтах;* 2. ш и л ж с э н юмыг дахин дахин үйлдэх; *үг давтах; давтан хэлэх;* **дахих давтах** х о р ш.; 3. сургуулилсан зүйлийг дахин сэргээх; *хичээл давтах;* 4. галтай зуухны яндангийн дээрээс салхи цохих; *утаа давтах;* 5. нэг ажлыг оролдон байтал дахин дахин дээрээс нь ажил нэмж ирэх; *ажил давцан давтах;* 6. буслыг дарах, дарлах; *дарлан давтах; доромжлон давтах* ᠳᠠᠪᠳᠠᠬᠤ

ДАВТЛАГА давтаж үйлдэх; *сурагчид давтлага хийж байна.* ᠳᠠᠪᠳᠠᠯᠭᠠ

ДАВТМАЛ давтаж хийсэн юм; *давтмал төмөр; давтмал газар.* ᠳᠠᠪᠳᠠᠮᠠᠯ

ДАВТУУЛАХ 1. давтахын үйлдүүлэх хэв; 2. давтагдах. ᠳᠠᠪᠳᠠᠭᠤᠯᠬᠤ

ДАВУУ илүү, сайн; *давуу чанар; энэ нь давуу морь байна; ажлаар давуу; амьдралаар давуу; чадлаар давуу; мэрэгжлээр давуу.* ᠳᠠᠪᠤᠤ

ДАВУУДАХ давамгай байх, хэтэрхий давуу болох, ахдах, илүүдэх. ᠳᠠᠪᠤᠤᠳᠠᠬᠤ

ДАВУУЛАХ 1. давахын үйлдүүлэх хэв; хир хэмжээнээс хэтрүүлэх, илүү болгох; *төлөвлөгөөг давуулан биелүүлэх; төсвийг давуулан зарцуулах;* 2. хэтэрхий цуудамнан хэлэлцэх; *чи дэндүү давуулж байна шүү.* ᠳᠠᠪᠤᠯᠬᠤ

ДАВУУРЬ индэр зэргийн өндөр дээр авиран гарах шат. ᠳᠠᠪᠤᠤᠷᠢ

ДАВУУСАХ давуутах. ᠳᠠᠪᠤᠤᠰᠠᠬᠤ

ДАВУУСГАХ давуу болгох. ᠳᠠᠪᠤᠤᠰᠭᠠᠬᠤ

ДАВУУТАХ улмаар давуу болох. ᠳᠠᠪᠤᠤᠲᠠᠬᠤ

ДАВУУТГАХ давуу болгох. ᠳᠠᠪᠤᠤᠲᠭᠠᠬᠤ

ДАВХАА а м ь т а н ам тэгш, төрс их, арьсаар нь өмсөх агуулах юм хийж болдог нэгэн зүйл загас. ᠳᠠᠪᠬᠠ

ДАВХАР 1. дан биш; *гурван давхар; давхар хашаа; давхар барьж оёх; давхар цамц;* 2. давхарлагатай; *давхар байшин; дөрөвдүгээр давхарт суудаг;* 3. нэг төрлийн биш, хэдэн янзын; *олон давхар ажилтай;* 4. зэрэг зэрэг; *давхар давхар хэлж санулахгүй бол болохгүй;* ☆ **бие давхар** (жирэмсэн); **бие давхар болох** (жирэмсэн болох); **давхар цэг** (бичигт хэрэглэх тэмдэг). ᠳᠠᠪᠬᠠᠷ

ДАВХАРГА I давхарлах эд юм, давхарласан юм; *гэрийн давхарга; дэвсгэрийн давхарга; давхаргатай гэр.* ᠳᠠᠪᠬᠠᠷᠭᠠ

ДАВХАРГА II нийгэмлэгийн улс төр, хууль цааз, шашин шүтлэг, урлаг, гүн ухааны үзэл санаа ба мөн түүнд зохицох улс төр, хууль цаазын зэрэг байгууллагууд; давхарга бол сууриас төрөн гарах бөгөөд мөнхүү суурийн бүрэлдэн тогтох, батжихад өөрөө нөлөөлдөг. ᠳᠠᠪᠬᠠᠷᠭᠠ

ДАВХАРГАДАС газрын тогтцын үе давхар; *хөрсний давхаргадас; чулуулгийн давхаргадас.* ᠳᠠᠪᠬᠠᠷᠭᠠᠳᠠᠰ

ДАВХАРГАЛАХ гэрт давхарлагаа барих; *гэр давхаргалах.* ᠳᠠᠪᠬᠠᠷᠭᠠᠯᠠᠬᠤ

ДАВХАРДАХ дахин дахин, байн байн давтагдах; *шүүмжлэл давхардаж байна.* ᠳᠠᠪᠬᠠᠷᠳᠠᠬᠤ

ДАВХАРДУУЛАХ давхардахын үйлдүүлэх хэв. ᠳᠠᠪᠬᠠᠷᠳᠤᠤᠯᠬᠤ

ДАВХАРЛАГ байшингийн давхар; *гуравдугаар давхарлагт суух;* **гуа давхарлаг** (театр зэрэгт байдаг давхар суудал). ᠳᠠᠪᠬᠠᠷᠯᠠᠭ

ДАВХАРЛАГА давхарлах юм; *гэрийн давхарлага.* ᠳᠠᠪᠬᠠᠷᠯᠠᠭᠠ

ДАВХАРЛАГЛАХ давхарлаг болгох. ᠳᠠᠪᠬᠠᠷᠯᠠᠭᠯᠠᠬᠤ

ДАВХАРЛАХ 1. юмыг давхар болгох; *гэр давхарлах; цонх давхарлах; утас давхарлан нийтгэх;* 2. давхар болох; *ажил давхарлаад амжихгүй болов.* ᠳᠠᠪᠬᠠᠷᠯᠠᠬᠤ

ДАВХАРЛУУЛАХ 1. давхарлахын үйлдүүлэх хэв; 2. давхарлагдах. ᠳᠠᠪᠬᠠᠷᠯᠠᠭᠤᠯᠬᠤ

ДАВХАЦ I. бороо, цас, хүйтнээс хувцас биеийг хамгаалан өрчлах цув дах мэт юм: цув **давхац; дах давхац** х о р ш.; 2. хувцас ба биед хир тоос, шороо тос халдах болон элэгдэх урагдахаас хамгаалан гадуур өмсөх хувцас. ᠳᠠᠪᠬᠠᠴ

ДАВХАЦЛАХ дээл хувцасны гадуур давхарлан давхац өмсөх. ᠳᠠᠪᠬᠠᠴᠯᠠᠬᠤ

ДАВХИЙХ 1. гэнт сочисхийх, чицавхийх; *давхийн эргэж харав;* 2. хөнгөн гавшгай хөдлөх. ᠳᠠᠪᠬᠢᠬᠤ

ДАВХИЛТ давхих үйлийн нэр; *давхилт сайтай морь.* ᠳᠠᠪᠬᠢᠯᠲ

ДАВХИУЛАХ давхихын үйлдүүлэх хэв; давхихад хүргүүлэх; *морь давхиулах.* ᠳᠠᠪᠬᠢᠤᠯᠬᠤ

ДАВХИХ довтлон явах; *мориор давхих; машинаар давхих.* ᠳᠠᠪᠬᠢᠬᠤ

ДАВХРАА I давхарлаж тогтсон юм; *давхраа хад; үүлний давхраа; давхраатай нүд.* ᠳᠠᠪᠬᠤᠷᠠ

ДАВХРАА II нийгэмлэгийн ба хүн амын доторхи анги болж чадахгүй хэсэг бүлэг; *хүн амын өргөн давхраа.*

ДАВХРААС давхрага, давхраа.

ДАВХРАЛ I а м ь т а н мөрөн голд төрнө, толгой мөрөгтэй адил, уруул зузаан, нурууны этгээд моголцог, өехийн этгээд түвшин, хайрс их, өнгө улаавтар нэгэн зүйл загас.

ДАВХРАЛ II цонхны гулд мод; *цонхны давхрал.*

ДАВХЦААХ давхцахад хүрүүлэх, давхцуулах.

ДАВХЦАХ зэрэг зэрэг давхарлан тохиолдох; *ажил давхцах; өвчин зовлон давхцах.*

ДАВХЦУУЛАХ давхцахын үйлдүүлэх хэв.

ДАВЦАН галт тэрэгний зогсоолын засмал өндөрлөг дэв.

ДАВЧ 1. чухал, бариу; *давч хувцас; давч өрөө;* 2. хэтэрхий богино, тулгам; *давч хугацаа; давч амьсгалах; давч ухаантай; яруу давч.*

ДАВЧДАХ 1. чухал, зай муутай болох; *дээлийн ханцуй давчдажээ;* 2. тулгамдах, хэтэрхий богино болох; *хугацаа давчдах;* 3. сандрах; бухимдах; *битгий давчдан сандар!;* 4. амьсгал бөглөрөн бачим болох; *дотор давчдах.*

ДАВЧДУУЛАХ давчдахын үйлдүүлэх хэв.

ДАВЧРАХ давч, давчуу болох; *дотор давчрах.*

ДАВЧУУ давч; **яруу давч** х о р ш . .

ДАВЧУУДАХ хэтэрхий давчуу болох.

ДАВЧУУРАХ давч давчуу болох.

ДАВЧУУРУУЛАХ давчуурахын үйлдүүлэх хэв.

ДАВЧУУСАХ улам давчуу болох.

ДАВЧУУСГАХ улам давчуу болгох.

ДАВЧУУСУУЛАХ давчуусахын үйлдүүлэх хэв.

ДАВЧУУТАХ давчуу зан байдал гаргах; *давчуутах хэрэг юун!.*

ДАВЧУУТГАХ давчуутахын үйлдүүлэх хэв, давчуухан болгох.

ДАВЧУУХАН нилээд давчуу, явцуухан.

ДАВЧХАН нилээд давч, **баахан давч.**

ДАВШГҮЙ давах аргагүй, дийлшгүй, баршгүй; *давшгүй даваа; давшгүй ажил.*

ДАВШИЛ давших нь; *давшил ихтэй; давшил муу.*

ДАВШИЛТ давших үйлийн явц; *давшилтэй хэрэг; давшилтгүй хүн; цэргийн давшилт; давшилт бүх хүн төрөлхтөн энх тайвны төлөө тэмцэж байна.*

ДАВШИЛХИЙЛЭХ 1. улмаар ахиж давших, урагшлах; 2. байн байн давшлах; *над давшилхийлэх хэрэг байна уу?.*

ДАВШИХ урагшлах, ахих; *цэрэг давших; ахиж давших; урагш давших.*

ДАВШЛАГА давшилт; *давшлагатай явдал.*

ДАВШЛАХ 1. байн байн давших; 2. урагш ухас ухасхийх, уурлан тэмүүлэх; *ташаагаа тулан давшлав; нохой давшлах.*

ДАВШУУЛАХ давшихын үйлдүүлэх хэв; ахиулах, урагшлуулах.

ДАГ I 1. хар хир, нэс муу; *даг болох; даг хиртэй;* **даг дайр** х о р ш . : 2. ш и л ж с э н азад, жигшүүр; **даг болох** (азад болох, жигшигдэх).

ДАГ II дандаа, үргэлж, байнга; *даг энүүгээр явах болов;* **даг үргэлж** х о р ш . *даг малгай өмсч суудаг.*

ДАГАА хөөмийч.

ДАГАВАР 1. дагасан юм; *дагавар хүүхэд; дагавар бичиг;* 2. үндсэн үгэнд угсран залгаж үгийн дүрс, утгыг хувилгах нөхцөл; *дагавар залгах; тийн ялгалын дагавар; дагавар үг.*

ДАГАЗНАХ түр зуур дагах.

ДАГАЗНУУЛАХ дагазнахын үйлдүүлэх хэв

ДАГАЛАЛЦАХ х у у ч и р с а н 1. хашин хөөх; 2. хариу заалдах.

ДАГАЛГА ном бичгийн доторхи үг өгүүлбэрийн уггыг тайлж тайлбарласан үг өгүүлбэр; *дагалга үг.*

ДАГАЛДАА урьдахийн дараа, дараа дараагаар, нэмэн нэмэн; *дагалдаагаар хөдлөв; аян хийгчид дагалдаагаар ирцгээв.*

ДАГАЛДАГЧ дагалдан явагч.

ДАГАЛДАН ажил дээр дагаж мэрэгжилд суралцагч; *дагалдан сурагч.*

ДАГАЛДАХ 1. дагахын үйлдэлдэх хэв, дагаж явах; *ерөнхий сайд дагалдан явагчдын хамт;* 2. даган дууриах, ойшоон зөвшөөрөх; *цөм дагалдан хашгирав; аядан дагалдах.*

ДАГАЛТ 1. дагаж явах зүйл; *дагалт бичиг; хамрын дагалт хөндий;* 2. хүндтэй этгээдийг дагаж явах хүмүүс; *дагалт нар.*

ДАГАЛХИЙЛЭХ дагахын дахин давтан үйлдэх байдал.

ДАГАЛЦАХ дагахын хамтран үйлдэлцэх хэв.

ДАГАСХИЙХ дагахын хурамхан үйлдэх байдал.

ДАГАХ 1. юмны хойноос бараадан явах; *тэрэгний хойноос нэг нохой дагаж явлаа; яс дагаж мах* х у у ч ; 2. ш и л ж с э н мөрдөх, журамлах; *заавар тушаалыг даган хөтлөв; хэв заншлыг дагах; нар дагах; зам дагах;* 3. ойшоон зөвшөөрөх; *ая дагах; үг дагах; санаа дагах; даган дууриах;* ☆ **дагаар орох** (сайн дураар харъяат болж захирагдах; *Монгол улсад дагаар оров);* **бух дагах** (үнээ буханд гарах).

ДАГАЦГААХ дагахын олноор үйлдэлцэх хэв.

ДАГДАРШИХ нягтрах, хатуурах; *шороо дагдарших.*

ДАГДАРШУУЛАХ дагдаршихын үйлдүүлэх хэв.

ДАГДГАНАХ 1. тогтвор тэсвэргүй дэгдгэнэх, хөдлөх; 2. тэсч чадахгүй чичрэх.

ДАГЖИХ бөмбөгнөтөл чичрэх; *дагжтал чичирч байв; шүд дагжих;* **чичрэх дагжих** х о р ш . .

ДАГЖРАХ 1. дагжих, чичрэх; 2. дагжуур болох; *газар дагжрах.*

ДАГЖУУЛАХ дагжихын үйлдүүлэх хэв.

ДАГЖУУР дардан хатуу газар; *дагжуур газар.*

ДАГЗ амьтны толгойн ясны ар шилийн орчин газар.

ДАГИР: дагир морь дан ганц; *дагир морио бүү даги.*

ДАГИУЛАХ дагихын үйлдүүлэх хэв.

ДАГИХ унаа малыг хэтэрхий давтан эдлэх; *дан морио дагиж хэрэггүй.*

ДАГЛАГАР данхгар.

ДАГЛАЙХ данхайх, даглагар болох.

ДАГНАА дагнаас.

ДАГНААС юмыг солонголж будахад будгийн нэг өнгийн зурвас; *дагнаас гаргаж будах.*

ДАГНААСЛАХ дагнаас гаргаж будах.

ДАГНАН үргэлжид, дандаа, байнга; *дагнан наадаж байж яаж болох вэ; дагна н мах идвэл бие муудна.*

ДАГНАХ I 1. халаа солиогүй ганцаар хийх; *өртөөний албыг дагнах;* **манаа дагнах** (ганцаар ээлжгүй манах); *нэг морь дагнаж унах;* 2. хурим найрт суугчид тус бүр нэжээд хул айраг уух; *дугараагаа дагнаа гэв;* 3. дан болгох; **гэрээ дагнах** (дан бүрээстэй барих); **ажлаа дагнах** (нэг ажлаа хийх); 4. дагнаас гаргаж будах.

ДАГНАХ II 1. юмыг хөлсөөр түр хэрэглэх; 2. эд юмыг барьцаанд бариулах.

ДАГНАХ III хөгжим хэрэглэхгүй, дан хоолойгоор уянгалан эгшиглэх.

ДАГНАХ IV дагнуураар газар хагалах; *газар дагнах.*

ДАГНИ 1. үлгэр туульд гардаг ид шидтэй гайхамшигт охин хүн; *тэнгэрийн дагни; лусын дагни;* 2. у р а н з о х и о л маш гуа үзэсгэлэнтэй эмэгтэй хүн; *гуа үзэсгэлэнгий чинь үзвэл, хурмаст тэнгэрийн дагни байна уу* (Учиртай гурван толгой).

ДАГНУУЛАХ дагнахын үйлдүүлэх хэв.

ДАГНУУР шороон бөөмийг хэмхчин няцлах хэрэгсэл; *төмөр дагнуур.*

ДАГТ (АН) даг II дагнан; *дагтан алдаа хийж байх юм.*

ДАГТАРШИХ дагдарших.

ДАГТАРШУУЛАХ дагтаршихын үйлдүүлэх хэв; *газар дагтаршуулах.*

ДАГТАХ 1. хар хир болох, хир буртаг болох; 2. азад болох, жигшигдэх.

ДАГТРАХ дагтарших.

ДАГТУУЛАХ дагтахын үйлдүүлэх хэв.

ДАГУУ 1. юмын уртын чигт; *голын дагуу; зам дагуу; дагуу ширхэгтэй; ширхгийн дагуу;* 2. ёсоор, нийцүүлэн; *хэлний дагуу; заавpын дагуу;* 3. сөрөг биш, эсэр тийш; *хивсээ үсий нь дагуу шүүрд.*

ДАГУУДАА туушдаа, нийтдээ, нэлдээ.

ДАГУУЛ дагуулсан юм; **дагуул эд (инж);** *дагуул хүүхэд; хиймэл дагуул.*

ДАГУУЛАХ дагахын үйлдүүлэх хэв.

ДАГУУЛБАР дагавар; *дагуулбар хүүхэд.*

ДАДААГҮЙ сайн сурч дасаагүй, дадлагажаагүй; *дадаагүй ажил далан зовлонтой.*

ДАДАЙХ дадгар болох.

ДАДАЛЗАХ дадгар юмны дадга дадга хөдлөх.

ДАДАМГАЙ үйл үйлдвэрт дадлага олсон; *дадамгай хүн;* **сурамгай дадамгай** х о р ш..

ДАДАХ дасах, дадлага олох; *ком унщиж дадах; бичиж дадах; морь унаж дадах.*

ДАДГА: дадга ладга хийх дадгар юмны үргэлжлэн хөдлөх.

ДАДГАНАХ дадгар юмны дадга дадга хөдлөх.

ДАДГАР 1. жижиг, бага; *дадгар биетэй хүүхэд;* 2. бариу, давч; *дадгар дээл.*

ДАДГАРДАХ хэгэрхий дадгар болох.

ДАДГАС: дадгас дадгас хийх дадгар юмны байн байн хөдлөх.

ДАДЛАГА сурч дадсан нь; *дадлагатай ажил хийхэд хялбар;* **дадлага туршлага** х о р ш..

ДАДЛАГАЖИХ дадлага туршлагатай болох; *тахиа маллах ажилд дадлагажсан хүн.*

ДАДЛАГАТАЙ дадлага олсон, дадлага бүхий; *дадлагатай ажилчин.*

ДАЖИН 1. дайны уршгаар гарах хүлгай дээрэм, үймээн самуун; *дайнаас дажин нь* х у у ч; **дайн дажин** х о р ш; 2. идэш хэрэглэхүүн маш ховордох; *дажин болох.*

ДАЙ дайлаас; *дай хийх; дай хадах; дайтай хүн.*

ДАЙВАЛЗАЛ дайвалзах үйлийн нэр, хэлбэлзэл.

ДАЙВАЛЗАХ ганхалзах, хэлбэлзэх, туйвалзах; *дүгүй нь сэнслэн дайвалзаж байжээ; хөл дайвалзах; завь дайвалзах.*

ДАЙВАЛЗУУЛАХ дайвалзахын үйлдүүлэх хэв.

ДАЙВАР 1. дайж болох аар саар тээшийн зүйл; *дайвар ачаа;* 2. худалдах юман дээр дайж дагалдуулан нэмж өх зүйл; ☆ **дайвар үг** (үйл байдлын болсон буюу болох орон, цаг мөн яаж болсон буюу болох байдал, хир хэмжээг заасан бүлэг үг).

ДАЙВАРЛАХ 1. дайх, дайж өгөх дайварлаж өгөх; 2. дайхад хүрүүлэх.

ДАЙВАХ ганхах, хэлбэрэлзэх, гуйвах; **гуйвах, дайвах** х о р ш..

ДАЙВГАНАХ гуйвганах, хайвганах, туйвганах.

ДАЙВГАР хөлийн хоёр өсгий нийлж хавиран явдаг; *дайвгар хөлтэй.*

ДАЙЗ 1. сум агуулах бүслэх уут; *сумны дайз; дайзтай сум;* 2. дайс; *шилбэ ороох дайз; дайз бүс.*

ДАЙЗЛАХ 1. сумыг дайзад агуулах; 2. дайз бүсээр ороох.

ДАЙЛААДАС дайлаас.

ДАЙЛААС модоор зүйж үйлдсэн юмыг холбон торгосон хөндлөн мод; *шалны дайлаас.*

ДАЙЛАЛ байлдал; **дайлал байлдал** х о р ш.

ДАЙЛАЛДААН байлдаан, тулалдаан.

ДАЙЛАЛДАХ дайтах, байлдах, тулалдах.

ДАЙЛАХ хүндэтгэн зочилж цайлах; *дайллага хийх; зочдыг дайлах.*

ДАЙЛАХ II дайтах, байлдах; *дайсны зэвсгээр дайлах.*

ДАЙЛАХ III модоор зүйж хийсэн эд юмыг хөндлөн торгож холбон бэхлэх; *шал дайлах; хаалга дайлах.*

ДАЙЛГА дайвар; *дайлга дайх.*

ДАЙЛГАЛАХ дайлахын үйлдүүлэх хэв.

ДАЙЛДААН байлдаан.

ДАЙЛДАХ байлдах, дайтах.

ДАЙЛЛАГА будаалга, цайллага; *дайллага хийх.*

ДАЙЛУУЛАХ 1. дайлахын үйлдүүлэх хэв; 2. дайлагдах.

ДАЙН улсууд буюу нийгэмлэгийн ангиудын хоорондоо хийх зэвсэгт тэмцэл; *дайн хийх; дайн болох; иргэний дайн; хүйтэн дайн; дайн өдөөгчид; дайны талбар; дайны эсрэг;* **дайн байлдаан; дайн дажин** х о р ш..

ДАЙР I 1. нухагдан гарсан яр шарх; *морины нь нуруу нухагдсаар дайр болов;* 2. вээр идээр болсон юм; *тохмын дайр;* **даг дайр х о р ш.; дайран дээр нь давс хийх** (улам цаашлуулах, хэтрүүлэх).

ДАЙР II буга; *дайр буга.*

ДАЙРАГДАХ дайрахын үйлдэгдэх хэв.

ДАЙРАЛДАХ 1. дайрахын үйлдэлдэх хэв; 2. тохиолдох, учрах; *би чамтай ноднин жил дайралдсанаас хойш дахин уулзсангүй.*

ДАЙРАЛДУУЛАХ дайралдахын үйлдүүлэх хэв.

ДАЙРАЛТ дайрах үйлийн нэр; *дайралт хийх*

ДАЙРАЛЦАХ дайрахын үйлдэлцэх хэв.

ДАЙРАХ 1. шүргэх, шүргэн түлхэж унагаах; *наад үхрээ хөө!, гэр дайрчих нь; хормойгоороо дайран унагаажээ;* 2. байгалийн үзэгдлийн болж өнгөрөх; *үер дайрах; хуй дайрах; нар дайрах; үүл дайрах;* 3. тохиолдох, дайралдах; *тойрч өнгөрдөггүй дайрч өнгөрдөг юм хууч;* 4. замд айл хунарт орох; *манайхаар дайраад явав; биднийг дайраарай!;* 5. басамжлах, доромжлох; *үгээр дайрах; дайрч давшлах; хүний муу, хүнийг дайрах;* 6. дайсан руу эрчимтэй довтлон орох; *монгол цэргүүд ура хашгиран дайран оров;* ☆ **саа дайрах** (гараг өвчин тусах).

ДАЙРЛАГА доромжлол; ☆ **дайрлага дайрах** (амьтны гэнэт үхэх).

ДАЙРТАХ 1. дайр гарах; 2. дайрын идээ шүүс наалдах.

ДАЙРТУУЛАХ дайртахын үйлдүүлэх хэв.

ДАЙРУУЛАХ 1. дайрахын үйлдүүлэх хэв; 2. дайрагдах.

ДАЙРЦГААХ дайрахын олноор үйлдэх байдал.

ДАЙРШИХ дайртай болох; *тохом дайрших.*

ДАЙС өвөөх боох оосорт зориулан хийсэн нарийн зурвас нэхмэл; *дайс бүс; дайс оосор.*

ДАЙСАГНАХ 1. дайсан болох, үзэн ядах, өшин хорсох; 2. хор хөнөөл учруулах; *над дайсагнах хэрэг байна уу?.*

ДАЙСАГНУУЛАХ 1. дайсагнахын үйлдүүлэх хэв; 2. дайсагнагдах.

ДАЙСАН 1. дайсагнаж байгаа этгээд, эсрэг этгээд; *ардын дайсан; бүрэлэй нар бол ажилчин анги ба хөдөлмөрчдийн эвлэршгүй дайсан мөн;* 2. байлдаж байгаа нөгөө этгээд; *дайсан бүт цохигдоно!, ялалт манай талд!;* 3. хор хөнөөл учруулагч; *малын дайсан-чоно; билчээр ургамлын дайсан-оготно.*

ДАЙСАНТАЙ өс өшөөтөн, хорлогчинтой, хөнөөлтэй.

ДАЙСЛАХ I дайсаар ороох боох.

ДАЙСЛАХ II 1. харилцан өшөөт дайсан бололцох, дайсагнах; 2 хор хөнөөл хүргэх.

ДАЙТАХ дайн хийх; *хоёр улс хоорондоо дайтаж байв.*

ДАЙТУУЛАХ дайтахын үйлдүүлэх хэв.

ДАЙХ 1. ачаан дээр нэмэн ачих тээх; *ачаан дээр нь авдраа дайж тавив; тэргэнд нь би дайгдаад хот оров; юмаа аян талын хөсөгт гүйж дайжээ;* 2. худалдах зүйлийн дээр өөр юмыг нэмэлт болгож тулган дагуулж өгөх.

ДАЙЧИН 1. алзахгүй сүрхий эр; 2. цэргийн эр, цэргийн хэрэгт туршлагажсан хүн, цэргийн төгс чанарт эр; *Зөвлөлтийн ялгуусан улаан армийн дайчид;* 3. хуучирсан цол.

ДАЙЧЛАГА дайчлах үйлийн нэр; *цэрэг дайчлага; хөдөлмөрийн дайчлага.*

ДАЙЧЛАГДАХ дайчлахын үйлдэгдэх хэв; *цэргийн албанд дайчлагдах.*

ДАЙЧЛАХ 1. албадан татах; *цэрэгт дайчлах;* 2. албадан гүйцэтгэх; *дайчлан баривчлах; дайчлан хураамжлах; морь дайчлан унах;* 3. зорнулах, шавхан гаргах; *нийтийн хэрэгт хамаг хүчээ дайчлах;* 4. дураар бусниулах; *эзгүйд нь тоглодог нөхөд нь гэрий нь дайчилж дайчилж явсан байлаа.*

ДАЙЧЛУУЛАХ 1. дайчлахын үйлдүүлэх хэв; 2. дайчлагдах.

ДАЛ I нурууны дээд орчинд байх өргөн хавтгай гурвалжин яс; **далаа хавчих** (даарах зэрэгт); **далны маяа** (дал ясны нарийн үзүүр хамрын хойтох яс); **далны тогоо** (дал ясны маяаны хонхор); **далны хамар** (далны урт тийш дагасан босоо яс); **далны хот** (дал ясны хамрын хажуугийн өргөн хавтгай); **далны мөгөөрс** (далны толгойн талд залгалдан орших мөгөөрс); **дал тавих** (дал шатааж толгодох); **далны хуудас** (далны дотор талын нимгэн мах; *далны хуудсыг далан хүн хуваж идэх).*

ДАЛ (АН) II долоон арвын нийлбэр тоо *дал нас хүрэх;* **далан долоон үг дэлгэх** (олон үг ярих); **далан худалч** (маш худалч); **далан давхар** (олон давхар); **далан давхар бин** (олон давхар болгон хийсэн бин); **далан хэлт чогчго** амьтан (бялзуухайн нам, хушуу шар, бие цох хар, хөл улаавтархан); **далан хальс** ургамал (хөх саарал, давхар дурстай, навч жижиг, шрхэг нягт хатуу, өнгө шаравтар нэгэн зүйл бут мод); **далан түрүү** ургамал (ганц үндэснээс бутлан салаалж ургадаг, навч ногоон саарал, үзүүртээ цом цэцэг-

гэй, олон наст ургамал, **төрөл зүйл олон**); **далан зангилаа** ургамал (**далан товчийн** нэг зүйл); далан **товч** ургамал (навчгүй, шилбэнийхээ үзүүрт товч мэт **бөмбөлөгтэй**, чийгэрхэг зөөлөвтөр хөрстэй газар ургадаг ургамал, төрөл зүйл маш олон).

ДАЛ III: **дал мод** ургамал өмнө газрын мод; мөчиргүй шулуун иштэй, маш том мөнх ногоон, өд буюу дэвүүр маягийн навчтай.

ДАЛ IV 1. бод малын хорио, **нөмөр** хорго; *дал саравч;* 2. наранд эзэвэр нөмөр сайтай газар; *хүйтэн жавартай өдөр дал газар дагуулж малаа хариулбал тохиромжтой.*

ДАЛ V: **дал дал хийх** хэл дэвсэн олон үг дэмий ярих; *дал дал хийсэн төвөгтэй хүн шүү.*

ДАЛААД дал орчим, дал шахам, дал хир; *далаад тэмээ.*

ДАЛАВЧ 1. шувуу, шавьжны нисэх жигүүр; *далавчаа дэлгэх;* 2. нисэх онгоцны даах хүчийг гаргах хавтаг; *давхар далавчтай онгоц;* 3. зарим юмны далбаа; *цонхны далавч; хаалганы далавч;* 4. **бөхийн** зодог; *бөх далавчаа өмсч байна.*

ДАЛАВЧДАХ бөхийн **далавчнаас** барих; *далавчдаж аваад дайрав.*

ДАЛАВЧЛАХ 1. шувуу шавьжийн жигүүр далавч ургах; 2. бөхийн зодгоо өмсөх; 3. барилдаж байгаа бөхийн нэг нь нөгөөгийнхөө зодгоос барих.

ДАЛАГНАХ I далан гарах, далан болох, далан хийх, далан болгох; газар **далагнах**; *дээл далагнах; ус далагнаж хөлдөх.*

ДАЛАГНАХ II далан бий болох; *адуу далагнах.*

ДАЛАГНУУЛАХ далагнахын үйлдүүлэх хэв.

ДАЛАЙ I дэлхийн усан бүрхэвчийн нэгэн хэсэг болох шорвог амттай гашуун ус бүхий үлэмж хэмжээний ус; *гадаад далай; Атлантын далай; Умард мөсөн далай; далайгаар аялах; далайд явах;* **далайд дусаал нэмэр** (нэмэр тус); **дөрвөн далай** (а. төрөх, өтлөх, өвдөх, үхэх; б. дөрвийн тооны ёгт нэр); **далайн боомт** (далайн ам сувийг хаасан бэхлэлт, усан онгоцны зогсоол); **далайн түвшин** (далайн усны түвшинг дунджаар тогтоож түүгээр газрын өндөр намыг тодорхойлох хөдөлбөргүй үндэс болгосон цэг); **далайн ам** (усан онгоцны зогсох боломж бүхий газар); **далайн дээрэмчин** (далайд зорчигчдыг уулгалах хэсэг); **далайн жүдчин** (далайд аялагч); **далайн нисэх хүчин** (далайн цэргийг хамгаалах нисэх онгоцны хэсэг); **далайн цэрэг** (усан замын цэрэг); **далайн загас** (далайд байдаг загас нийтийн нэр, бүгд 10000 орчмоос 7000 илүү нь далайд оршино); **далайн таван хушуут** амьтан (далайд орших өргөст амьтны анги, бие таван хушуутай, заримд нь 40 орчим салаа хушуу бий); **далайн од** амьтан (далайн таван хушуутын нэг зүйл); **далайн зараа** амьтан (далайн сээр нуруугүйтний анги; хэлбэр бөмбөг, өндөг, зээрэнцэг мэт янз янз байх бөгөөд зараа шиг шивүүр зүүтэй загас); **далайн зарьяа** амьтан (зараа загасны төрлийн нэг зүйл загас); **далайн заан** амьтан (усны ирвэсийн нам, далбаа хөлтний язгуурын нэгэн амьтан, урт нь 6—7 метр, эрийн хамар урт тул заан гэж нэрлэжээ, гадаад далайн өмнөд этгээдээр бий, түүнийг өөх ба арьсны төлөө агнана); **далайн илжиг** амьтан (янз илжигтэй адил, усанд орших бөгөөд хөхөл нь огт нордоггүй нэгэн зүйл амьтан); **далайн морь** амьтан (арьс зузаан, өнгө хар бараан, бараг үегүй, соёо урт, ам том, бие хүнд бөгөөд урт, сүүн тэжээлт, сэлүүр хөлтөн амьтан; арьс, өөх, мах, соёог ашиглана); **далайн дорго** амьтан (янз дорготой адил, арьсы нь ашиглаж болно); **далайн нохой** амьтан (сүүгээр бойждог том биетэй амьтны ерөнхий нэр, дотроо төрөл ялгал олон); **далайн арслан** амьтан (сэлүүр хөлтний нам, бие том, 2—3,5 метр урт, хүнд нь 350—700 кг. хүртэл, эрийн хүзүү, цээж хэвэл орчимд дэл зогдортой, далайд оршино, төрөл зүйл олон); **далайн чоно** амьтан (янз хулгана мэт, урт нь 134 см. хүнд нь 20 кг. хүрдэг, далайд амьдрах нэг зүйл загас); **далайн туулай амьтан** (биений урт 2,5 метр, хүнд нь 250 кг. хүрдэг; нуруун тал, үсний өнгө хар саарал, заримын нуруунд том цагаан толбо бий, өөхий цагаан саарал, мөс цасанд нүх ухаж оршдог, сүүн тэжээлтэй том амьтан, агнаж арьс өөхийг ашиглана); **далайн наймалж** амьтан (хавьсны хоёр хажуу шовхгор, хойт хоёр хөл салаагүй, хөлийн үзүүр этгээд хавтгай, хавтасны үзүүрт сондуутай нэгэн зүйл хорхой, далайд оршино); **далайн мөгөөрс** амьтан (хэлбэр чийрсэн бүрх малгайн адил, хөндлөн гулд хэд хэдэн тохой их, толгой нүд гэдэс дотор байхгүй, сам хорхойн хүчийг түшиж дэгдэн явдаг усны амьтны махыг идэг болно); **далайн гахай** амьтан (хушуу шувуныхтай адил, шүд жижиг 240 хүрдэг, сэлүүр хадуур мэт хэлбэртэй, нуруу толгой хар; хажуу бөөр, гэдэс цагаан; биеийн урт нь 2,5 метр хүрдэг, далайн усны өнгөн хэсгийн жижиг загасыг иддэг, эм нь үрээ 10 сар тээнэ, идэш эрж далайд сүрэг сүргээр явна, агнаж өөх, мах, арьсыг ашиглана); **далайн шулмас** амьтан (сондуут загасны язгуур, урт нь 2

метр хүрнэ, дүрс байдал маш сонин, толгой их, ам өргөн, нуруундаа сондуутай, аман дээр унжилзууртай, өмнөт живэр урт, Хар ба Дундад тэнгэст бий, идэж болно); **далайн ван хавч** а м ь т а н (хавчийн нэгэн зүйл, далайн гүнд оршино; бие шил мэт, нэвт үзэж болно, нүд маш их, цэцгий нь гурван хувийн нэгийг эзэлнэ); **далайн сам хорхой** а м ь т а н (янз голын сам хорхойтой адил боловч бие том); **далайн цахлай** а м ь т а н (янз цагаан тахианы адил, ар бие нь үнсэн өнгөтэй, жигүүр бараан, сүүл цагаан; зарам, сам хорхой иддэг шувуу): **далайн тотиг** а м ь т а н (бие бараавтар, ар ба омруу цагаан, эрхий байхгүй нэгэн зүйл шувуу); **далайн тагтаа** а м ь т а н (хөвчин бие нь үнсэн хөх өнгөтэй, хүзүүндээ нэгэн үе хар чандартай, хөл шийр цайвар улаан шувуу); **далайн урьдал жимс** у р г а м а л (иш модны өндөр 3—4 тохой илүү, өвөл цэцэглэх бөгөөд цэцгийн хүйс маш жижигхэн, жимс интор мэт их, нэгэн зүйл жимс); **далайн дал мод** у р г а м а л (янз хялгаст модонд адил, навч ишний үзүүрт хуниастан ургана, ишинд хялгас арьс байхгүй); **далайн дун мод** у р г а м а л (янз нарстай адил, туулайн бөөр мэт болоод арай жижиг, гурван уулзар бүхий үртэй нэгэн зүйл мод); **далайн цагаан ногоо** у р г а м а л (далайд ургана; өнгө хөхөвтөрхөн, навч өргөн бөгөөд урт, идшинд хэрэглэдэг); **далайн саргай цэцэг** у р г а м а л (мөнх ногоон бутархаг модонд ургадаг, хөх буюу цагаан өнгийн цэцэг); **далайн ван** з у р х а й (нарны аймгийн найм дахь гараг, энгийн нүдэнд үл үзэгдэнэ).

ДАЛАЙ II 1. их; *яндаж болдоггүй далай шиг яасан баян нутаг вэ!; зовлонгийн далайгаас гэтэлж жаргалын далайд хүрэв;* 2. цол; *далай даян; далай сэцэн;* **Далай лам** (шарын шажны толгойлогч).

ДАЛАЙЛГАХ I далайхын үйлдүүлэх хэв.

ДАЛАЙЛГАХ II бусдыг айлгах, сүрдүүлэх; *үгээр далайлгах; сүр далайлгах; далайлгаж байж авахыг оролдов; албан тушаалаар далайлгах.*

ДАЛАЙЛГУУЛАХ далайхын үйлдүүлэх хэв.

ДАЛАЙХ юмыг жанчих, цохих, цавчихыг завдан гар буюу зэвсэг өргөх; *гар далайх; сэлэм далайх; сух далайтал үхэр амар* з үй р.

ДАЛАЙХАС у р г а м а л салааны үзүүрт том навчтай, навчнаас 3—4 иш гарч намуу цэцгийн адил цэцэг хонгорцоглон ургана, цэцэглэсний дараа гилбэгнэм сайхан өнгөтэй нэгэн зүйл цэцэг.

ДАЛАЙЦ 1. далайх үйлийн явц; *далайц нь их боловч буулт нь хөнгөн* з үй р; 2. ш и л ж с э н үйл ажиллагааны хэмжээ, чадал; *их далайцтай хөдлөх; хувьсгалын далайц.*

ДАЛАЙЧ (ИН) далайгаар аялагч хүн.

ДАЛАН I 1. ус намгийг хааж шороо чулуугаар хийсэн бооц; *шороон далан;* 2. усыг хаасан арал; *далан арал;* 3. усыг хаасан нарийн зурвас газар *бооц далан;* 4. тариалангийн тарьсан газрын хоорондын зай буюу журам газар; *шаа далан;* 5. урт гөвгөр нуруу буюу аараг хуруу ихтэй хуудсарсан газар; *далан нуруу; далан хуудас;* 6. юмны бүлхийн унжсан газар, хаваас суларснаас буюу өнгө дотрын аль нэг нь агшиж нэг нь сунаж унжсан газар; *дээлийн далан.*

ДАЛАН II барилгын дээврийн хөмрөн тавьсан ваар; *дээврийн далан ваар.*

ДАЛАН III 1. адуу луус зэрэг амьтны дэл ургасан газар; 2. адууны дэл бүхий газрын дагуугийн зурвас цулцан; *адууны далан; даага далантай, бяруу булчинтай;* 3. зарим нутагт харвинг далан гэх нь бий; **харвин далан** х о р ш..

ДАЛАН IV модны ур.

ДАЛАНЛИГ усыг хааж халхлан хийсэн далан мэт зүйл.

ДАЛАНТАА далан удаа.

ДАЛБАА I 1. ишинд уяж хийсгэх бөс, торгомсгоор хийсэн зүйл; *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын далбаа; төрийн далбаа; улаан далбаа намиран хийсч байна;* **туг далбаа** х о р ш.; 2. завь онгоцны дарвуул; *онгоцны далбаа нь цайран харагдав; 3. хаалганы далавч, хавтас;* 4. усны амьтны сэлэх эрхтэн, сэлүүр.

ДАЛБАА II бөхийн зодог.

ДАЛБААТ далбаатай; *далбаат онгоц.*

ДАЛБАГА: далбага далбага хийх далбагар юмны үргэлжлэн хөдлөх.

ДАЛБАГАЙ юмны ам амсар гадагш дэрэвгэр буюу тэлүүн; *далбагай амсартай аяга.*

ДАЛБАГАНАХ далбагар юмны далбага далбага хөдлөх.

ДАЛБАГАНУУЛАХ далбаганахын үйлдүүлэх хэв.

ДАЛБАГАР эв хавгүй, хавтгай том; *далбагар малгай; далбагар мөөг; далбагар навч.*

ДАЛБАЙЛГАХ далбайхын үйлдүүлэх хэв.

ДАЛБАЙХ далбагар болох; *далбайсан том навч.*

ДАЛБАЛЗАХ далбагар юмны далбас далбас хөдлөх.

ДАЛБАЛЗУУЛАХ далбалзахын үйлдүүлэх хэв.

ДАЛБАН далбагар юм.

ДАЛБАРАХ урагдах, навсрах, лаврах.

ДАЛБАС: далбас далбас хийх далбагар юмны байн байн хөдлөх.

ДАЛБАХ салхинд дэгвэгнэн хийсч хөдлөх; *салхинд өрх далбах; туг хийр далбах; ачаа барааны бүтээлэг далбах.*

ДАЛБИГА: далбига далбига хийх далбигар юмны үргэлжлэн хөдлөх байдал.

ДАЛБИГАЙ далбигар.

ДАЛБИГАНАХ далбигар юмны далбига далбига хөдлөх.

ДАЛБИГАНУУЛАХ далбиганахын үйлдүүлэх хэв.

ДАЛБИГАР хавтгай том бөгөөд эв хавгүй хэлтийдүү далбин юм; *далбигар малгай; далбигар таваг.*

ДАЛБИЙЛГАХ далбийхын үйлдүүлэх хэв.

ДАЛБИЙХ далбигар болох.

ДАЛБИЛЗАХ далбигар юмны далбис далбис хөдлөх.

ДАЛБИН том хавтгай бөгөөд эв хавгүй, далбигар; *далбин малгай.*

ДАЛБИС: далбис далбис хийх далбигар юмны байн байн хөдлөх.

ДАЛД I илийн эсрэг; *далд газар; далд хийх; далдаас ажиглан зогсов; нүд далд; далд орох;* **далд үе (илрээгүй үе); далдын далд** (бүр далд, маш далд).

ДАЛД II у р г а м а л ууланд ургадаг, хайлсны навчтай адил болоод том, ховол модны дурстай адил дурстай нэгэн зүйл мод.

ДАЛДАВЧ 1. юмыг халхлах, далдлахад зориулан хийсэн зүйл; 2. хаалганы тушаа цогцолсон сав, хэрэм.

ДАЛДАВЧЛАХ юмыг далд болгох, хааж халхлах.

ДАЛДАЛХИЙЛЭХ юмыг далдлан нуух, хааж халхлахыг оролдох.

ДАЛДАЛХИЙХ хэл дэвсэж нялганан хэлэлцэх; *далдалхийсэн ямар жигтэй амьтан бэ?*

ДАЛДАХ дал орчноос барих; *далдаж аваад гуядав.*

ДАЛДАХЬ I далд байгаа юм; *ил байсан нь дууссан тул далдахийгаа гаргаж үзүүлэв.*

ДАЛДАХЬ II далдугаар.

ДАЛДИРАА зүрх муутай, аймхай.

ДАЛДИРАМТГАЙ далдирамхай .

ДАЛДИРАМХАЙ далдирах зантай, аймхай

ДАЛДИРАХ 1. цохихоос зайлсхийн нүдээ анивчин толгойгоо гэнэт хажуу тийш татах; *цохиулж хаширсан мэт далдирах;* 2. айж бэрхшээх.

ДАЛДИРУУЛАХ далдирахын үйлдүүлэх хэв.

ДАЛДИЧАА байн байн далдирдаг.

ДАЛДИЧИХ *байн байн далдирах.*

ДАЛДИЧУУР далдичаа.

ДАЛДЛАГЧ нуугч, халхлагч.

ДАЛДЛАХ далд болгох, нуух, халхлах; **нуух далдлах** х о р ш.; *далдлалгүй ярих.*

ДАЛДЛУУЛАХ далдлахын үйлдүүлэх хэв.

ДАЛДУГААР дэс дараагийн тоо, дал дахь; *далдугаар хуудсанд*

ДАЛДУУ I царс ба хар хус модонд ургадаг жимс мэт зүйл, чанаж идвэл болно, бусад модонд ургасныг идэж үл болно.

ДАЛДУУ II у р г а м а л анхилмал үнэртэй, балт цэцэгтэй, шүдтэй шомбогордуу хэлбэртэй навчтай мод; *тэмээн далдуу; үхэр далдуу.*

ДАЛДУУР нууцгай, эчнээ, битүү; *далдуур муулах.*

ДАЛДУУРЛАХ далд болох, нууц байлгах.

ДАЛЖГА: далжга далжга хийх далжгар юмны үргэлжлэн хөдлөх.

ДАЛЖГАНАХ далжгар юмны далжга далжга хөдлөх.

ДАЛЖГАР нэгэн этгээд тийш хазгай хэлбэрүү: *далжгар хүзүүтэй; далжгар эвэртэй үхэр.*

ДАЛЖИЙЛГАХ далжийхын үйлдүүлэх хэв.

ДАЛЖИЙХ далжгар, далжгай болох, нэгэн гийшээ хазгай хэлбэрүү болох; *далжийсан хүзүүтэй.*

ДАЛЖИЛЗАХ далжгар юмны далжис далжис хөдлөх.

ДАЛЖИЛЗУУЛАХ далжилзахын үйлдүүлэх хэв.

ДАЛЖИР далжгар.

ДАЛЖИС: далжис далжис хийх далжгар юмны байн байн хөдлөх.

ДАЛЖУУ хэлбэрүү; **хэлбэрүү далжуу** х о р ш.

ДАЛИВС у р г а м а л дэлгэрэнгүй цэцгийн төрлийн далбагар том навчтай ургамал.

ДАЛИГА: далига далига хийх далиу юмны үргэлжлэн хөдлөх.

ДАЛИГАНАХ далиу далигар юмны далига далига хөдлөх.

ДАЛИГАР далиу, далжир.

ДАЛИЙЛГАХ далийхын үйлдүүлэх хэв.

ДАЛИЙХ далиу болох, гажиж хазайх; *далийсан эвэртэй үхэр; далийж харах.*

ДАЛИЛЗАХ далиу юмны дальс дальс хөдлөх.

ДАЛИМ ялдар, дашрам, аянтал; *энэ далимд би тантай нэг зүйлийг ярилцаад орхиё; түүний далимаар; явдлын далим харъя.*

ДАЛИМДАХ 1. ямар нэгэн үйл явдлын зэрэгцээгээр өөр үйл явдлыг хамтатган гүйцэтгэх; 2. зай сэмхийг завшин ашиглах; *эжийн эзгүйг далимдаж явна.*

ДАЛИМДУУЛАХ далимдахын үйлдүүлэх хэв; 1. нэгэн хэрэг ажлын дашрамд ямар нэгэн үйл явдлыг ялдар гүйцэтгүүлэх; 2. ямар нэгэн зүйлээр завшаан шалтгаан болгох; *албан ажлаар далимдуулан өдий төдий хоног хэсч тэнэж явсан ажээ.*

ДАЛИМЛАХ далимдах, далим харах, далим гаргах.

ДАЛИУ галжир солжир, хазгай сариу, далир далжир, тэгш тэнцүү биш; *далиу эвэртэй шар; далиу толгойтой; далиу нүдтэй.*

ДАЛИУДАХ хэтэрхий далиу болох.

ДАЛИХ хэвийн байдлаас гажиж далиу болох; *банз далих; нум далих.*

ДАЛЛАГА 1. даллаж өгөх дохио; 2. буян хишиг гуйх зан үйлийн нэр; *даллага авах.*

ДАЛЛАХ 1. хүнийг ир гэж гар буюу алчуур мэтийг эргүүлэн дохио өгөх; *далайсан газар чинь далд орж. даллаасан газар чинь ил гарч явъя* (үлгэр); *тэр хүн даллаж байна очъё;* 2. буян хишиг хурайлан дуудах.

ДАЛЛУУЛАХ даллахын үйлдүүлэх хэв.

ДАЛУУЛ хам тоо, далан тооны юм; *бид далуул мордов.*

ДАЛЧ дал шатааж төлгөдөх хүн.

ДАЛЬ I у р г а м а л ойт уулын орой хяраар ургадаг, гол төлөв ягаан цэцэгтэй, үнэр анхилам, шөвгөр уртлаг навчтай, мөнх ногоон жижиг мод; Эмнэлэг, үнэртний зүйлд хэрэглэнэ.

ДАЛЬ II шувууны далавч.

ДАЛЬС: дальс дальс хийх далиу юмны байн байн хөдлөх.

ДАМ I дамжигдаж уламжлагдаж ирэх, явуулах юм; *дамын үг дамжигтай; дам хэл явуулав; дам дам уламжилж хэл хүргээрэй; дам дам тараа!;* **дам сонсох** (бусдаас сонсох); **дам хүн** (бусад хүн); **дам гишгүүр** (онгоцноос буух суухад усны зах хүртэл агдлан тавьсан модон гишгүүр); **дам илд** (урт иштэй том илд); **дам нуруу** (байшин барилга, хаалганы дээд талын сул нуруу); **дам энэх** (хаалга үүдний дээр хөндлөн тавьсан бат зузаан мод); **дамын наймаа, дамын худалдаа** (бусдаас авсан юмыг ашиг хичээж үнэ нэмэн худалдах худалдаа); **дамын наймаачин, дамын худалдаачин, дамын панзчин** (мөлжимтгий худалдаачин); **дамынхан** (дамын худалдаачид).

ДАМ II арга, дадал, туршлага; *дамыг олох; дамыг авах.*

ДАМ III саад, хөндөл; *дам тавих; дам хийх.*

ДАМ IV тооны нэр; арван аравжам, 13 оронтой тоо.

ДАМ V а м ь т а н далайд оршдог, шаахайн ул мэт хэлбэртэй загас.

ДАМАР 1. утсаар оосорлосон хоёр товч цохилууртай, хоёр талдаа ширтэй хөгжмийн зэвсэг; *дамар цохих; урианы дамар;* 2. дундуураа нарийн хэлбэртэй дамар мэт юм; *машины дамар.*

ДАМАРДАХ дамрыг сэжлэн дуугаргах.

ДАМАРЛАХ хүн бусдыг доогхийн наадах; *чи битгий дамарлаад байгаарай.*

ДАМЖАА буддын шашны ёсны судар тарнийн аймаг ухааны номлолд анги дэвшин сурагчаж төгсөхөд ба зэрэг авахад өгөх шалгалт; *домын дамжаа; гавжийн дамжаа; аграмбын дамжаа; дамжаа барих.*

ДАМЖИГ эргэлзээ, омтгой; *надад дамжиг бүү сана.*

ДАМЖИГГҮЙ эргэлзээгүй, омтгойгүй, осолгүй; *дамжиггүй үнэн байна.*

ДАМЖИГТАЙ эргэлзээтэй, омтгой, осолтой; *дамын үг дамжигтай.*

ДАМЖИХ 1. нэг юмнаас нөгөө дээр шилжин гишгэж явах; *чулуун дээгүүр дамжин горхийг гарав; шатаар дамжин явах;* 2. нэг газраас нөгөөд шилжин хэсэх; *хот дамжих; газар орон дамжих;* 3. нэг этгээдээс нөгөөд шилжих; *гар дамжих; цусаар дамжих; амьсгалаар дамжих.*

ДАМЖЛАГА дамжих үйлийг хүлээж байгаа юм, дамжуурга; **дамжлага баз** (юм дамжуулах үүрэг бүхий газар): **үйлдвэрийн дамжлага** (үйлдэж байгаа юмыг дам дамжуулан гүйцэтгэх ажиллагаа).

ДАМЖЛАХ юмыг хамжин өргөх; *хоёул дамжлах; дөрвүүл дамжлах.*

ДАМЖЛУУЛАХ дамжлахын үйлдүүлэх хэв.

ДАМЖУУЛАГЧ дамжуулдаг юм; *дамжуулагч этгээд; тог дамжуулагч;* **хагас дамжуулагч** (цахилгааныг муу дамжуулах юмс).

ДАМЖУУЛАХ дамжихын үйлдүүлэх хэв, дам дам уламжилж хүргэх; *үг дамжуулах; захиа дамжуулах; түйпуу дамжуулах;* **дамжуулах чанар** (юмны цахилгаан дамжуулах чадал)

ДАМЖУУЛГА дамжлага.

ДАМЖУУЛУУР дамжуулах юм, дамжуулан хөдөлгөх юм.

ДАМЖУУР 1. хоёр үзүүрт нь юм зүүж мөрөн дээрээ тавин мөрлөж явах мод буюу төмөр, дамнуур ч гэнэ; 2. ус гатлахаар энд тэнд тавьсан мод чулуу мэтийн зүйл; ☆ **дамжуур царцаа** амьтан (нэгэн зүйл царцаа).

ДАМЖУУРГА 1. дамжин явахад зориулан энд тэнд тавьсан чулуу мэтийн юм; 2. дамнуурга; 3. гишгүүр шат мэт үелэн хийсэн зүйл; *дамжуурга ширээ.*

ДАМЖУУРГАЛАХ дамжуургаар дамнан явах.

ДАМЖУУРЛАХ юмыг дамжуураар дамжлан явах.

ДАМЛААЧИН дамын худалдаа хийгчид.

ДАМЛАХ I юмыг дамлан худалдах: *хоршооноос авсан юмаа дамлан худалдаж болохгүй.*

ДАМЛАХ II дамнах.

ДАМЖУУЛАХ дамлахын үйлдүүлэх хэв.

ДАМНАГАЛЗАХ шийдвэрлэн чадахгүй сэжиглэн тээнэгэлзэх.

ДАМНАГАЛЗУУЛАХ дамнагалзахын үйлдүүлэх хэв.

ДАМНАГДАХ 1. дамнахын үйлдүүлэх хэв; 2. хөшилдөх, тээглэх, дамналдах.

ДАМНАЛДАХ 1. ямар нэгэн урт юмны хөндөлдөн хэвтэх; *гэрийн урьдуур багана дамналдан хэвтлээ;* 2. хөшилдөх тээглэх.

ДАМНАЛДУУЛАХ дамналдахын үйлдүүлэх хэв.

ДАМНАХ 1. дамнуургаар юмыг гөнжүүрлэн тээн явах; *ус дамнах; хоёул дамнах;* 2. хүнд хөнгөнийг гараар өргөлхийлэн тэнсэж үзэх; 3. шилжсэн ямар нэгэн юм, юмны дээгүүр хөндөлдөн орших, дамналдах.

ДАМНУУЛАХ дамнахын үйлдүүлэх хэв.

ДАМНУУР дамнуурга.

ДАМНУУРГА 1. юмыг дамнан явахад хэрэглэх хэрэгсэл; *тэрэгний дамнуурга; усны дамнуурга;* 2. хүн ба хүнд юмыг дамжлан зөөх хэрэгсэл; *шороог дамнуургаар зөөв; өвчтөний дамнуурга.*

ДАМНУУРЧИН дамнуур дамнан явах хүмүүс.

ДАМПУУ 1. ажлаа эмхэлж чадахгүй болсон, ажлаа алдсан, ажил нь завхарсан; *дампуу хүн;* 2. эдэлж чанар муутай болсон, хүүршсэн, хуучирсан юм; *дампуу эд; дампуу хуулга.*

ДАМПУУРАЛ 1. дампуурах үйлийн нэр; 2. хөрөнгөт нийгэмлэгт өрөө төлөхийг зогсон ажил явдал нь завхрах, балрах; 3. шилжсэн бүрмөсөн чадваргүй болох, балрах; *халдан довтлогчдын бодлогын дампуурал.*

ДАМПУУРАХ 1. дампуу болох, ажлаа алдан завхрах; 2. хүүршиж чанар муудах.

ДАМПУУРУУЛАХ дампуурахын үйлдүүлэх хэв.

ДАМСАГ гайхам хуурамч сүр; **дамсаг гаргах** (хуурам сүр гаргах).

ДАМСАГЛАХ гайхмаар хуурамч сүр гарган авирлах, дамшиглах ч гэнэ.

ДАМТАХ юмны халхлагдан далдлагдах.

ДАН I 1. нэгэн зүйлээр бүтсэн, өөр хольцоогүй; *дан шөл; дан мах;* 2. давхаргүй; *дан дээл; дан майхан; дан өлзий; дан ширхэгтэй;* 3. ижилгүй, ганц; *дан биеэр явах; дан морьтой аялах.*

ДАН II урьд гол урсч байсны ором журам газар; *голын дан.*

ДАН III багтаамжийн хэмжээ, арван бяцхан дүү; *нэг дан цагаан будаа.*

ДАН IV: **дан царцаахай** а м ь т а н тариалан ургамлын навчийг идэж сүйтгэдэг нэг зүйлийн царцаа.

ДАН V: **дан дан хийх, дан дун хийх** хатуу юмны харшилдсан чимээ сонсдох; *дан хийтэл цооролов гэнэ.*

ДАН VI ямагт, дандаа.

ДАНАЙЛГАХ данайхын үйлдүүлэх хэв.

ДАНАГАР биерхэг, том, бадриун, үзэмж сайтай, сайхан; *данагар морь; данагар ширээ; данагар ташуур; данагар мод; данагар малгай.*

ДАНАГАРДАХ хэтэрхий данагар болох.

ДАНАГАРХАН баахан данагар, арай данагар.

ДАНАЙХ данагар болох, сайхан харагдах.

ДАНАЛЗАХ данагар юмны чадамгайрхан хөдлөх аашлах; *даналзсан сайхан морь унасан хүн явна; тэр гуай ч даналзаж яваа харагдана билээ.*

ДАНАЛЗУУЛАХ даналзахын үйлдүүлэх хэв.

ДАНАН: данан бялзуухай бөвөөлжин шувууны өөр нэр.

ДАНГИНАТАЛ дангинах үйлийн байдал; *дангинатал хөлдөх; дангинатал баглах; дангинатал хатах.*

ДАНГИНАХ 1. хангинах; дан дан хийх; 2. ш и л ж с э н ид хүчтэй болох, чангарах, ширүүсэх; *хүйтэн дангиналаа; ус дангинатал хөлдөв; дангинатал хүлэх;* 3. ш и л ж с э н түргэн гавшгай, шаламгай байх; *дангинасан хүн; дангинатал баглах; дангинатал цэгцлэх;* 4. зандран аашлах; *дарга маань дангинаж байв; түүний дангинах нь аргагүй бизээ!.*

ДАНГИНУУЛАХ дангинахын үйлдүүлэх хэв; дангинахад хүргүүлэх; *ажлаа дангинуулчихсан байлаа.*

ДАНДАА 1. үргэлж, байнга, ямагт; *дандаа салхилж байдаг газар; дандаа тийм зантай хүн; дандаа хэл ам таталж явах хэрэг юун!;* 2. цөмөөрөө бүгдээр; *дандаа миний танил нөхөд; дандаа үеийн хүмүүс; дандаа цагаан морь унасан байв.*

ДАНДАЙ шатарцахад ноёныг цохрөлтгүй шалах шалаа: **дандай хийх** (үргэлжлэн шалж нүцэгрүүлэх).

ДАНДАЙЛАХ дандай хийх; *шатрын ноёныг дандайлах.*

ДАНДАЙЛГАХ дандайхын үйлдүүлэх хэв.

ДАНДАЙЛУУЛАХ дандайлахын үйлдүүлэх хэв.

ДАНДАЙХ дэндийх, дандгар болох.

ДАНДАЛЗАХ дэндэлзэх.

ДАНДАХ I дагнуураар шорооны бөөмийг хэмхчин няцлах; *шороо дандах.*

ДАНДАХ II дан болоод тохиромжгүйдэх; *гэр дандаад хүйтэн байна.*

ДАНДГАНАХ дэндгэнэх.

ДАНДГАР дэндгэр.

ДАНДУУЛАХ дандах I II-ын үйлдүүлэх хэв.

ДАНЖ юм зээлүүлэхэд барьцаалах юм; *данж барьцаа; данж бариулах;* **данжийн пүүз** (данж барьж мөнгө зээлдүүлэн өгөх газар).

ДАНЖААД 1. гэрийн эзэн, өрхийн тэргүүлэгч; 2. ш и л ж с э н пүүзний эзэн.

ДАНЖИЧ мөнгө хүүлэгч этгээд.

ДАНЖЛАХ данж барьж юм зээлүүлэх.

ДАНЖЛУУЛАХ данжлахын үйлдүүлэх хэв.

ДАНИС бууны бянт засах багаж.

ДАНИСДАА з у р х а й сарны зурхайн ёсны 28 одны нэгийн нэр.

ДАНС аливаа юмыг жагсаан тэмдэглэж бичсэн бичиг дэвтэр; *бичиг данс; орлого зарлагын данс; эд хөрөнгийн данс; дансны би-*

чээч; данс хөтлөх; дансанд тэмдэглэх; **данс хар** (аливаа хэрэг зүйлийг сийрүүлэн бичсэн байцаал болгох товхимол бичиг дэвтэр); **данс нээх** (харилцах данстай болох); **дансанд оруулах** (дансанд бүртгэх); **харилцах данс** (банканд мөнгө хадгалуулах данс); **төсөвлөсөн данс** (төсвийн данс): **ашиг алдагдлын данс** (ашиг орлогын данс).

ДАНСГҮЙ данс бүртгэл байхгүй, дансанд ороогүй; *дансгүй зүйл ширхэг ч байж болохгүй.*

ДАНСЛАХ юмыг дансанд бичиж тэмдэглэх, бүртгэх; *эд хогшлоо данслах; мал сүргээ данслах; орлого зарлагаа данслах.*

ДАНСЛУУЛАХ данслахын үйлдүүлэх хэв, бүртгүүлэх.

ДАНСТАЙ дансанд орж бүртгэгдсэн, дансанд бий юм; *данстай хогшил.*

ДАНХ 1. цай агуулах сав; *цайны данх; данхтай цай;* 2. цавуу хайлах сав.

ДАНХАГА: данхага данхага хийх данхгар юмны үргэлжлэн хөдлөх;

ДАНХАЙ шагаа зэргээр наадахад хожигдож дахин өрөхөд харьцах тоонд хүрэхгүй боловч нэгэн удаа тооцож тоглох нь.

ДАНХАЙЛГАХ данхайхын үйлдүүлэх хэв.

ДАНХАЙХ данхгар болох.

ДАНХАЙЦАХ данхай наадах.

ДАНХАЛЗАХ данхгар юмны данхас данхас хөдлөх; *толгой нь данхалзах; эвэр нь данхалзах.*

ДАНХАР данхгар; *данхар толгой.*

ДАНХАРХАН баахан данхгар.

ДАНХАС: данхас данхас хийх данхгар юмны байн байн хөдлөх байдал.

ДАНХГАНАХ данхгар юмны данхга данхга хөдлөх.

ДАНХГАР юмны толгой буюу дээд этгээд хэтэрхий том, дэнхгэр; *данхгар толгойтой; данхгар эвэртэй хайнаг,*

ДАНХГАРДАХ дэндүү данхгар болох.

ДАНХИГА: данхига данхига хийх данхигар юмны үргэлжлэн хөдлөх байдал.

ДАНХИГАНАХ данхигар юмны данхига данхига хөдлөх.

ДАНХИГАР хэвийн хэмжээнээс янхигар том, данхигар.

ДАНХИГАРДАХ дэндүү данхигар болох.

ДАНХИГАРХАН баахан данхигар.

ДАНХИЙЛГАХ данхийхын үйлдүүлэх хэв.

ДАНХИЙХ *данхигар болох; данхийсан ямар өндөр хүн бэ?*

ДАНХИЛЗАХ данхигар юмны данхис данхис хөдлөх байдал.

ДАНХИР данхигар.

ДАНХИС: данхис данхис хийх данхигар юмны байн байн хөдлөх байдал.

ДАРАА I 1. хожим сүүлд; *дараа баяртай! дараа ирэхэд чинь бэлэн болгоё; чамайг явсны дараа; нэг сарын дараа;* 2. ирэх; *дараагийн сайн өдөр; дараагийн сард;* 3. байн байн, дахин дахин; дараа дараагаар, удаа дараагаар; 4. дэс, зэрэг, эримбэ; *зэрэг дараа; дэс дараа; дараагий нь олох; дараа боть.*

ДАРАА II тээр, дараас, саад, садаа; *энэ нэг явдал над дараа болж байна.*

ДАРААЛАЛ дараалах үйлийн нэр; *дараалал хийх; дараалалтай болгох; үсгийн дараалал; зүйлийн дараалал.*

ДАРААЛАХ 1. дараатай болгох; *хуудас дараалах; үсэг дараалах;* 2. дараа үл алгасах; хоцроохгүй; *хуудас дараалан уншу; толгой дараалан бүртгэ!.*

ДАРААЛУУЛАХ дараалахын үйлдүүлэх хэв.

ДАРААС тээр дараа, дарсан юм; *дараасыг ав!; над энэ л дараас болж байна.*

ДАРААСЛАХ дараас болох.

ДАРААХАН баахан дараа, мөдхөн; даруйхан; *нар шингэсний дараахан ирэв.*

ДАРААХЬ дараагийнх; *дараахь ээлж; дараахь дугаар.*

ДАРААЧ дараахь, ирэх; *дараачийн долоо хоног; дараачийн сайн өдөр.*

ДАРАВГАЙ даравгар; *даравгай амтай;*

ДАРАВГАНАХ даравгар юмны дарвага дарвага хөдлөх.

ДАРАВГАНУУЛАХ даравганахын үйлдүүлэх хэв.

ДАРАВГАР ам амсар их ангархай, тэлүүн, *даравгар амтай; даравгар шарх.*

ДАРАВЧ 1. юмыг дарах бооход зориулан **хийсэн зүйл;** *дуулганы даравч; хурамсганы*

даравч; 2. зарим, голдуу эрэгчин шувууны хөлд ургасан эвэржүү зүйл; *эр тахианы даравч; гургуулын даравч;* 3. мөрин цэргийн гуглын өсгийд хийж, морио шавдах төмөр; *гутлын даравч.*

ДАРАГДАХ дарахын үйлдэгдэх хэв; *тоосонд дарагдах; ажилд дарагдах; цасанд дарагдах; өвчинд дарагдах; насанд дарагдах.*

ДАРАГДУУЛАХ дарагдахын үйлдүүлэх хэв; *бичиг дарагдуулах.*

ДАРАЙЛГАХ дарайхын үйлдүүлэх хэв.

ДАРАЙХ даргар болох; *шир хатаж дарайв; үгаасан юм гадаа хүйтэнд дарайтал хөлдөөн байжээ.*

ДАРАЛЗАХ даргар юмны дарс дарс хөдлөх.

ДАРАЛТ 1. ямар нэг талбай дээр гарч байгаа дарах хүч; **агаарын даралт** (нэг дөрвөлжин см. талбайд гаргаж байгаа даралт); 2. юм дарах зүйл: **хөхний даралт** (эмэгтэйчүүдийн хөхийг ороож уях даруулга); **хэвлэлийн даралт хуудас** (хэвлүүлсэн зүйлийг тооцоолох нэгж хэмжээ); **бичгийн даралт** (бэх уух цаас); 3. даруулга; *хаалганы даралт; цонхны даралт; даралт төмөр.*

ДАРАЛХИЙЛЭХ дарахын дахин давтан үйлдэх байдал.

ДАРАЛЦАХ дарахын хамтран үйлдэлцэх хэв.

ДАРАМ I амьтны нуруу дагуугийн газар; *үхрийн дармын арьс.*

ДАРАМ II хэмжээс; **алга дарам** (алга дарж хүрэлцэх хэмжээ); **хуруу дарам** (а. хуруу дарж хүрэлцэх хэмжээ; б. хуруу дарж тоолмоор цөөхөн).

ДАРАМТ дарж байгаа нь, тээр дараа болох юм; *дарамтыг арилга; дарамттай хэрэг.*

ДАРАМТЛАХ 1. дарамт болох; 2. дарлах.

ДАРАМТЛУУЛАХ 1. дарамтлахын үйлдүүлэх хэв; 2. дарамтлагдах; 3. дарлагдах.

ДАРАНГУЙ I чангалан захирсан нь; **дарангуй цэрэг** (нэгэн этгээдээс нөгөө этгээдийг чангалан сэргийлж, сахин сүүлгасан цэрэг).

ДАРАНГУЙ II даруу номхон; *дарангуй зантай.*

ДАРАНГУЙЛАХ 1. урьдаас чангалан сургах; *хүүхдээ сайн дарангуйлж байдаг байв;* **дарангуйлан захирах засаг** (төрийн эрхийг барьсан ангийн нөёрхолт төр): **пролетарийн дарангуйлан захирах засаг** (улсын эрхийг ажилчин анги барьсан төр); 2. чангалан баримталж захирах.

ДАРАНГУЙЛУУЛАХ дарангуйлахын үйлдүүлэх хэв.

ДАРАР борголжин сахал.

ДАРАХ 1. юмны дээрээс доош болгохоор хүчдэх; *өвс нуруулдахад дээрээс нь олигтойхон дарах хэрэгтэй байдаг; доош нь дарах; няц дарах; чулуугаар дарах;* **өндөг дарах;** (шувуу өндөгнөөсөө ангаахай гаргахын тул дээрээс нь суух); **хуруу дарах** (а. эрхий хуруунаас эхлэн нэг хоёр гэж хуруугаар тэмдэглэн тоолох; *хуруу даран тоолох;* б. нуусан хурууг олохоор наадах; в. таах төлөгдөхөд эрхийгээр бусад хурууны үсийг тохиолдуулан тоолох); 2. юмны хэв дүрсийг юман дээр гаргах; *бар дарах; тамга дарах;* **эрхий дарах** (эрхий хурууны ормыг бичиг дээр гаргаж баталгаа болгох); 3. намжуулах, намхруулах, бууруулах, хорогдуулах, хасах; **амьсгаагаа дарах** (түр амсхийх); **уураа дарах** (уураа барих); **нас дарах** (өндөр насалж, тамир тэнхэл муудах); **үнэ дарж авах** (үнэ хорогдуулах); **царай дарах** (а. өөдгүй царай гаргах; б. царай нь гутах); **сүр дарах** (а. сүрдэх; б. жавхаагий нь гутаах); **цалин дарах** (цалингаас нь суутгах); 4. доош нь болгох; *хярд гарсан малыг дараад ирэв; сайн хүнийг өндийлгэхгүй дарахын хэрэг юун!;* **толгой дарах** (а. толгойгоо гудайлгах; б. толгой дараалах); 5. далдлах, бүрхэх; *эрийг нас дарж ,уулыг цас дардаг;* **хог дарах** (а. хог новш их болох; б. хог новшийг булах, далдлах); **шороо дарах** (юман дээр шороо тоос үлэмжхэн хурж тогтох); 6. давхцах, дээр дээрээс нэрмэх; **ажил дарах** (олон ажил давхцах): **хөл дарах** (олон хүн зэрэг-зэргээр давхцан ирэх); 7. нууц далдлах; *малын тоог дарах; алдуул малыг даржээ;* **насаа дарах** (залуу болох гэж насаа бага хэлэх); 8. юмыг хадгалах, нөөцлөх; **ногоо дарах** (ногооны зүйлийг давсалж хадгалах); **бараа дарах** (дамын худалдаачид элбэг барааг хоёр болоход нь өндөр үнээр худалдана гэж нөөцлөх); **ажиг дарах** (тус хорыг тэмдэглэн санаандаа хадгалах); 9. ялах, устгах; *дайсныа дарж дархан цолыг олов, өстнөө дарж өргөн цолыг олов* у л г э р; **нүх дарах** (а. нүхийг битүүлэх, бөглөх; б. нүх шахаж наадахад даалууны нүхийг хөмрөн нуух); 10. хойноос нь мөрдөж хөөх, гүйцэх; *дайсны араас шил даран хөөж сүүл даран байлдаж сөнөөв;* ☆ **хар дарах** (аймаар зүүд зүүдлэх); **толгой даран** (цөм, бүгдээр); **дарж бичих** (яаралгүй-хичээн бичих).

ДАРВАГА: дарвага дарвага хийх даравгар юмны үргэлжлэн хөдлөх.

ДАРВАЙЛГАХ дарвайхын үйлдүүлэх хэв, дарвайхад хүргүүлэх.

ДАРВАЙХ даравгар болох, ам амсар мэтийн ангайх, онгойх; *армана гэдэг амьтны асар том ам дарвайн харагдав; дарвайсан том амтай нохой явна.*

ДАРВАЛЗАХ даравгар юмны дарвас дарвас хөдлөх.

ДАРВАС: дарвас дарвас хийх даравгар юмны байн байн хөдлөх.

ДАРВИА дарвимтгай.

ДАРВИАН 1. дүйвээн, чимээ, шуугиан; *энэ сонсдож байгаа дарвиан хаанаас гарав?;* 2. хөхөөл, хөгжөөн; *дарвианд гүйх;* **үймээн дарвиан** х о р щ..

ДАРВИАНТАЙ дарвиан бүхий, хөгжөөнтэй, шуугиантай.

ДАРВИГНАХ 1. ирвэгнэх, бадайрах; *гар хөл дарвигнах;* 2. хэлэнд халуун гашуун амт сэрэгдэх; *хэл дарвигнах.*

ДАРВИГНУУЛАХ дарвигнахын үйлдүүлэх хэв.

ДАРВИМТГАЙ дарвих зантай.

ДАРВИМХАЙ дарвих дуртай.

ДАРВИУЛАХ дарвихын үйлдүүлэх хэв.

ДАРВИХ бие биедээ татагдан хөөрөх, хөвсрөх; *хүүхэд дарвиж хөөрөлдөн бужигнав.*

ДАРВУУЛ онгоцны далбаа.

ДАРГА I тэргүүлэх, удирдах, толгойлох үүрэг тушаал хүлээсэн хүн; *газрын дарга; хэлтсийн дарга; цэргийн дарга нэгдлийн дарга; нарийн бичгийн дарга.*

ДАРГА II: дарга дарга хийх даргар юмны үргэлжлэн хөдлөх.

ДАРГАЛАХ даргын үүрэг гүйцэтгэх, толгойлох; *хурал даргалах; байгууллагыг даргалах.*

ДАРГАЛУУЛАХ даргалахын үйлдүүлэх хэв.

ДАРГАНАХ даргар юмны дарга дарга хөдлөх.

ДАРГАР дардгар, дэргэр, хатуувтар; *дардгар зузаан цаас; даргар шир.*

ДАРГИА шингэн юмны оргилж байгаа байдал; *булгийн даргиа усны даргиа.*

ДАРГИАН дарвиан, хөгжөөн; *наргиан даргиан.*

ДАРГИАХ даргихад хүргүүлэх.

ДАРГИЛ чулуурхаг хэвгий газраар урсах усны ширүүн урсгал; *даргил газрын ус нимгэн байдаг.*

ДАРГИЛАХ шингэн зүйлийн ихэд оргилох, буцлах; *тогоотой цай даргилан буцлав; ус даргилан урсах.*

ДАРГИЛГАХ даргихад хүргүүлэх, даргиулах.

ДАРГИЛУУЛАХ даргихын үйлдүүлэх хэв.

ДАРДАЙХ дардгар болох.

ДАРДАЛЗАХ дардгар юмны дардас дардас хөдлөх.

ДАРДАС I дарсан юм; *хэвлэлийн дардас хуудас; дардас чулуугий нь ховхлов.*

ДАРДАС II дардас дардас хийх дардгар юмны байн байн хөдлөх.

ДАРДГА: дардга дардга хийх дардгар юмны үргэлжлэн хөдлөх.

ДАРДГАНАХ дардгар юмны дардга дардга хөдлөх.

ДАРДГАР даргар дарсгар; *дардгар шир; дардгар мод.*

ДАРДГАРДАХ хэтэрхий дардгар болох.

ДАРДГАРХАН баахан дардгар, арай дардгар.

ДАРЖГАР дэржгэр, салхинд хялбар хийсмээр байдалтай нимгэвтэр юм; *даржгар нэхий.*

ДАРЖГАРДАХ хэтэрхий даржгар болох.

ДАРЖИГ I: даржиг даржиг хийх даржгар юмны тар тар хийх.

ДАРЖИГ II шашны ёсны нэг зүйл жижиг дарцаг; *хий морь даржиг.*

ДАРЖИГНАХ даржгар юмны даржиг даржиг чимээ гарах; *байшингийн орой дээр хатгасан далбаа даржигнан хийсч байв.*

ДАРЖИГНУУЛАХ даржигнахын үйлдүүлэх хэв.

ДАРЖИЛЗАХ даржгар юмны даржис даржис хийх.

ДАРЖИЛЗУУЛАХ даржилзахын үйлдүүлэх хэв.

ДАРЖИН ядуу хоосон; *даржингийн зовлон дааны хэцүү.*

ДАРЖИС: даржис даржис хийх даржгар юмны байн байн дуугарах чимээ гарах.

ДАРИУЛАХ дарихын үйлдүүлэх хэв.

ДАРИХ найр хуримд хүмүүс халамцаж дарвин уух.

ДАРЛАГА даруулга.

ДАРЛАГДАХ дарлахын үйлдэгдэх хэв; *Дорно дахины дарлагдсан ард түмэн эрх чөлөөгөө олов.*

ДАРЛАГЧ дарладаг этгээд; *дарлагч анги; дарлагч ангийн дарангуйлан захирах засаг.*

ДАРЛАЛ дарлах үйлийн нэр; **дарлал мөлжил** хорш.; *колонийн дарлал.*

ДАРЛАЛЦАХ дарлахын хамтран үйлдэлцэх хэв.

ДАРЛАМТГАЙ дарлах зантай.

ДАРЛАМХАЙ бусдыг дарлахдаа сурамгай.

ДАРЛАНГУЙ дарлагч, дарлах зантай.

ДАРЛАХ I доромжлон харгислах; *ард түмнийг феодалууд дарлан мөлжиж байв; чи битгий дарлаад бай!.*

ДАРЛАХ II байн байн дарах; *нуруу дарлах.*

ДАРЛУУ зан омог дээрэнгүй, дарламтгай; *дарлуу зан гаргах.*

ДАРЛУУЛАХ 1. дарлахын үйлдүүлэх хэв; 2. дарлагдах.

ДАРМАЛ дарсан юм; **дармал бараа** (а. хээ дармаллаж хийсэн торго бөс; б. дарж хадгалсан бараа); **дармал бичиг** (а. хэвээр дармалласан бичиг; б. хичээнгүйлэн бичсэн бичиг); **дармал дарах** (ном бичиг хэвлэх); **дармал бордоо** (дарш); **дармал ногоо** (удаан хэрэглэхээр даршилсан ногоо).

ДАРМАЛЛАХ 1. ном бичиг мэтийг хэвлэх; 2. бөс торгонд хээ дармал гаргах.

ДАРМАЛЛУУЛАХ дармаллахын үйлдүүлэх хэв.

ДАРС I их төлөв усан үзмээр хийх архи; *улаан дарс; шар дарс; үзмийн дарс;* **архи дарс** хорш.; **дарсан чулуу** (дарсны хүчлээс авсан калийн давс).

ДАРС II: **дарс дарс хийх** дарсгар юмны байн байн хөдлөх.

ДАРСАГА: дарсага дарсага хийх дарсгар юмны үргэлжлэн хөдлөх.

ДАРСГАНАХ дарсгар юмны дарсга дарсга хөдлөх.

ДАРСАЙЛГАХ дарсайхад хүрүүлэх, дарсгар болгох.

ДАРСАЙХ дарсгар болох, дардайх.

ДАРСАЛЗАХ дарсгар юмны дарс дарс хөдлөх.

ДАРСГАР даргар, дардгар, арзгар, барзгар; *дарсгар төмөр; дарсгар үдээр;* **дарсгар шоовин** (нэгэн зүйл идээ).

ДАРСЧ дарс хийх мэрэгжилтэй хүн.

ДАРУЙ удалгүй, сааталгүй; **даруй түргэн** хорш.; *нэн даруй хариуг ирүүл!; энэ мэдээг даруй хүргэх хэрэгтэй; тэр даруй нь мэдсэн.*

ДАРУЙХАН хурдхан, түргэхэн, бушуухан.

ДАРУУ 1. юмны сэжүүр доош болсон, гудайсан; *даруу хормойтой дээл; даруу зовхи;* 2. шилжсэн эгэл, жирийн, гялгар цэлгэр биш; *даруу өнгө;* **даруу бууруу** хорш.; 3. шилжсэн зан байдал номой, номхон, төлөв; *даруу зантай хүн.*

ДАРУУЛ I дарлага, даралт.

ДАРУУЛ II тахиаг хашин хорих торон оромж; *тахианы даруул.*

ДАРУУЛ III загасны дээрээс нь хөмрөн хорьж барих тор; *загасны даруул.*

ДАРУУЛАХ 1. дарахын үйлдүүлэх хэв; 2. дарагдах; **эм даруулах** (эмийг шингэн юмаар уух; *энэ эмийг шөлөөр даруулж уу!);* **ачаа даруулах** (юмыг ачааны татлагын дор тогтоох, торгох).

ДАРУУЛГА I 1. юмыг дарахад хэрэглэх зүйл; *гэзэгний даруулга; эмээлийн даруулга:* 2. ачаа дээр дайсан юмыг дарж бэхлэх оосор; *даруулга дээс;* 3. хуягийн гадуур өмсөх ширээр хийсэн өмсгөл; 4. саадаг хоромсгоны хоншоор зэргийн бэхлээ төмөр.

ДАРУУЛГА II хэв ёсыг журамлуулах сургамж; *даруулга сайн бол хүмүүжил сайн.*

ДАРУУЛДАХ 1. ачааг даруулгаар тогтоон торгох; 2. шувууг хөмөрч хорих; 3. загасыг даруулаар агнах.

ДАРХ I эдлэл юмыг гараар хийх мэрэгжсэн ажил; **ур дарх** хорш.; *дарх хийх.*

ДАРХ II **эрх; эрх дарх** хорш.

ДАРХАД 1. дархлагдсан хүмүүс; 2. монголын нэг ястны нэр; *Хөвсгөлийн дархад*.

ДАРХАН I дарх хийхэд чадамгай хүн; *төмрийн дархан модны дархан; дархны газар; дархны багаж; дархан хүн; уран дархан.*

ДАРХАН II 1. урьдын цагт алба татвар зэргийг үзэхгүй эрх олсон хүн; 2. ховор ан амьтан ургамал зэрэг юмыг үржүүлэх ба хамгаалах зорилгоор авах болон авлахыг улсаас хориглон цаазалсан газар; *дархан цаазтай газар;* 3. цол хэргэм; *дархан бээл; дархан ван;* **дархан аврага** (улсын наадамд түрүүлсэн аврага цолтой хүнд олгох цол).

ДАРХИ унанги том мод.

ДАРХИГА: дархига дархига хийх дархигар юмны үргэлжлэн хөдлөх байдал.

ДАРХИГАНАХ дархигар юмны дархига дархига хөдлөх.

ДАРХИГАР янхигар, том биетэй; *дархигар том гар.*

ДАРХИЙЛГАХ дархийхын үйлдүүлэх хэв, дархигар болгох.

ДАРХИЙХ дархигар болох.

ДАРХИЛЗАХ дархигар юмны дархис дархис хөдлөх.

ДАРХИЛЗУУЛАХ дархилзахын үйлдүүлэх хэв.

ДАРХИРАХ олон хүний тэмцэлцэн гүйх, өрсөлдөх.

ДАРХИС: дархис дархис хийх дархигар юмны байн байн хөдлөх.

ДАРХЛАГДАХ дархлахын үйлдэгдэх хэв, *дархлагдсан хүн; дархлагдсан газар.*

ДАРХЛАХ I дархны багаж зэвсгээр юм үйлдэх; *нэг авдар дархалж суув.*

ДАРХЛАХ II дархан болгох; *алба татвараас дархлах; газар ус дархлах.*

ДАРХЛУУЛАХ 1. дархлахын үйлдүүлэх хэв; 2. дархлагдах.

ДАРХНАГ цахиур бууны хонгилын дотор дарь хийх газар; *бууны дархнаг.*

ДАРХЧУУД дарх хийдэг хүмүүс.

ДАРЦААГААР дараа дараагаар буюу залгаагаар дахин дахин болох; *удаа дарцаагаар.*

ДАРЦАГ хийсэх эдээр хийсэн иш бүхий жижиг далбаа; *дарцаг хийсгэх.*

ДАРЦАХ дараа дараагаар болох, давхцах.

ДАРЦУУЛАХ дарцахын үйлдүүлэх хэв, давхцуулах.

ДАРШ 1. малд зориулж ургамлыг ногоон үед нь навч, нахиа, иштэй нь дарж хадгалсан тэжээл; *эрдэнэ шишийн дарш; даршийн нүх;* 2. дарсан булсан юм; *дарш аргал;* **булш дарш** х о р ш..

ДАРШЛАХ дарш хийх, дарш болгох; *нэгдэл бүхэн эрдэнэ шиш даршилсан байв.*

ДАРШЛУУЛАХ даршлахын үйлдүүлэх хэв.

ДАРЬ галт зэвсгийн цэнэг хийх тэсрэх бодис; *утаагүй дар; дарь хүхэр* х о р ш.; *дарины сав;* **дарь умшлах** (дарийг мөхлөг болгох); **дарь үсэргэх** (дарь шатаах); **дарийн умш** (дарийн мөхлөг).

ДАСАЛ дасах үйлийн нэр; *дасал болох;* **ижил дасал** х о р ш.; **ижил дасал болох** (харилцан ижилдэх).

ДАСАМГАЙ харилцан ижилдэж дассан нь; **дасамгай сурамгай** х о р ш..

ДАСАМТГАЙ дасах зантай, хялбар дасах нь.

ДАСАМХАЙ дасамтгай.

ДАСАХ 1. занших ,сурах; *харанхуйд нүд дасах; дассан газрын даавуу зөөлөн* з ү й р; 2. дотно болох, харилцан ижилдэх; *хүнд хялбар дасдаг.*

ДАСГАЛ ямар нэгэн үйл ажилд сурч дадах тогтмол ажиллагаа; *дасгал хийх; дасгалын хураамж; биеийн тамирын дасгал.*

ДАСГАЛЖИХ дадаж боловсрох; дасгал хийх.

ДАСГАЛЖУУЛАГЧ дасгал хийлгэгч.

ДАСГАЛЖУУЛАХ дасгалжихын үйлдүүлэх хэв, дасгал хийлгэх.

ДАСГАЛЧ дасгалжуулагч.

ДАСГАХ дасахын үйлдүүлэх хэв, дасахад хүргүүлэх; *биедээ дасгах; хөдөлмөрт дасгах.*

ДАХ хүйтний цагт хувцасны дээрээс үсий нь гадагш нь харуулан өмсөх хувцас; *ямаан дах; чоной дах; даарахад дах эрдэнэ.*

ДАХИАД дахин давтан; *дахиад нэг хэлье; дахиад дуулаач; дахиад бичи!*

ДАХИВАР дахилт.

ДАХИН I давтан; *дахин хийх; дахин явах;* **дахин давтан** х о р ш.; *дахин давтан хэлэх; дахин дахин;* **ахин дахин** х о р ш . .

ДАХИН II даяар, *дэлхий дахин; Ази дахин.*

ДАХИУЛАХ дахихын үйлдүүлэх хэв, дахихад хүргүүлэх.

ДАХИХ дахин давтан үйлдэх; *муу бол дахиж хийнэ; дахиад нэг туршив; олон дахин унш.*

ДАХЛАЙ намар буюу орой төрсөн дорой хурга ишиг; *дахлай хурга.*

ДАХЛАХ дах өмсөх.

ДАХЛУУЛАХ дахлахын үйлдүүлэх хэв.

ДАЦАН шашны ёсны лам хуврагийн сургуулилах орон сүм; *чойр дацан; зурхай дацан; мамба дацан; барүун дацан.*

ДАШ I: **даш хадаг** хамгийн жижиг хадаг, гялгар ч гэдэг; *хээгэй даш; цоохор даш.*

ДАШ II дээлийн зах тойрон хадсан үс, саа утас.

ДАШИМГАЙ бялдууч, нийлүүлэгч.

ДАШИМГАЙЛАХ бялдуучлах, ая байдалд нь дагаж нийлүүлэх.

ДАШИНГА 1. туурганд гогтоож хийсэн юм хум тавих банз; *номоо даншига дээр өрж тавьсан байв;* 2. горхи, суваг, шуудуу зэргийг гатлахад зориулан тавьсан банз мод.

ДАШИНГАТ хувцас хунир агуулах хаалгагүй олон өрөөтэй тавиур шүүгээ.

ДАШИХ хир хэмжээнээс хэт явах.

ДАШЛАХ нэгэн албан тушаалын орон тоонд хоёр хүний нэр дэвшүүлэхэд түүний дэст орох; *цохлох дашлах; тушаалд дашлах.*

ДАШЛУУЛАХ дашлахын үйлдүүлэх хэв.

ДАШМАГ 1. шингэн зүйлийг агуулах сав, төмөрлөгийн зүйлээр хийнэ, хэлбэр их төлөв дугараг; *гуулин дашмаг; архины дашмаг;* 2. мах зууш хайрч боловсруулах хайруул тавag

ДАШРАМ далим, ялдам, дагуу; *би ажлын дашрамд гэрээрээ оров.*

ДАШРАМДУУ дашрамдах далимдах зантай

ДАЯАН ш а ш н ы аглагт сууж хийх бясалгал: **даяан хийх, даяанд суух** (бясалгал үйлдэж суух):

ДАЯАНЧ 1. даяан хийх хүн; 2. мах цээрлэдэг хүн.

ДАЯАНЧЛАХ даяанч болох.

ДАЯАР нийт, хотлоор; *даяар амгалан тайван; нийт даяарын баяр.*

ДАЯГ төвд монгол хоёр хэлний толь бичиг.

ДАЯГА: даяга даяга хийх даягар юмны үргэлжлэн хөдлөх.

ДАЯГАНАХ даягар юмны даяга даяга хөдлөх.

ДАЯГАР хөл тулгуур гадагш саригар муруй; *даягар хөлтэй ширээ.*

ДАЯИЙХ даягар болох.

ДАЯЛЗАХ даягар юмны даяс даяс хөдлөх.

ДАЯЛЗУУЛАХ даялзахын үйлдүүлэх хэв.

ДАЯН хамаг, бүх, даяар; *даян дэлхий;* **даян аврага** (улсын их наадамд аврага цолтой барилдаж түрүүлбэл түүнд олгох чимэг цол).

ДАЯС: даяс даяс хийх даягар юмны байн байн хөдлөх.

ДЕБЕТ орлого зарлагын дансны авлага, өрийг тэмдэглэх хүснэг

ДЕБЕТОР өртэй этгээд.

ДЕЖУР ямар нэгэн сахих сэргийлэх, ээлж халаатай албан үүрэг гүйцэтгэгч, *цагдан сэргийлэх газрын дежур; төмөр замын станцын дежур; цахилгаан мэдээний дежур; телефон утасны дежур; жир хүн биш, дежур хүн;* **дежурийн дэлгүүр** (бусад дэлгүүрүүдийг амарч байх завсар ажиллах дэлгүүр).

ДЕЖУРЛҮҮЛЭХ дежурлэхийн үйлдүүлэх хэв.

ДЕЖУРЛЭХ дежурийн үүргийг гүйцэтгэх.

ДЕКАН дээд сургуулиудын факультетийн дарга; *нийгмийн ухааны факультетийн декан.*

ДЕПАРТАМЕНТ зарим хөрөнгөтөн орны яамд, засаг захиргаа, шүүх цаазны дээд байгууллагын нэр; *төрийн департамент.*

ДЕПО галт тэрэг байрлах ба засварлах газар; *галт тэрэгний депо.*

ДЕПУТАТ төрийн байгууллагын сонгогдсон төлөөлөгч; *Улсын их хурлын депутат; аймг-*

гийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа (аймгийн депутатуудын хурлаар сонгогдсон захиргаа).

ДЕСАНТ 1. дайсны талын нутаг дэвсгэрт эсрэг этгээдийн гэнэт буух дэрэг; *десант буулгах;* 2. мөн аргаар буусан цэрэг; *агаарын десант; далайн десант.*

ДЕЦИГРАММ хүндийн хэмжээ, 100 мг.

ДЕЦИМЕТР метрийн аравны нэг хувь буюу арван см.

ДИАГНОЗ оношь.

ДИАГРАММ жишиг зураг; *диаграмм хийх; боловсон хүчний өсөлтийн диаграмм.*

ДИАЛЕКТИК байгаль ,нийгэм, сэтгэхүйн хөгжлийн ерөнхий хуулийг судлах ухаан; диалектик материализм (марксист-ленинист намын ертөнцийг үзэх үзэл).

ДИАМЕТР голч шугам дув дугуй тойргийн нэг захаас төвийг дайруулан нөгөө зах хүртэл татсан шулуун шугам.

ДИВААДАД үйл үйлдвэр хийхэд тотгор хөнөөл бологч; *үймүүлээд ажил хийлгэхгүй сүрхий диваадад билээ.*

ДИВААДАДЛАХ диваадад болох.

ДИВАН хэвтэх суухад зориулан түшлэг багарын тавиуртай урт зөөлөн сандал; *диван дээр суух.*

ДИВИЗ хэд хэдэн хорооноос бүрэлдсэн цэргийн нэгдэл анги; *морьт дивиз; танкийн дивиз; моторт дивиз.*

ДИВИЗИОН 1. их буу, морьт цэрэг, хуягт танкийн цэргийн салбар; *танкийн дивизион;* 2. нэг төрлийн хөлөг онгоц бүхий далайн цэргийн анги.

ДИДЭН: дидэн цэцэг ургамал бут бутаар үргэлжлэн ургадаг, араа бүхий навчтай, өнгө шар, хүйс дүгрэг, үнэргүй нэгэн зүйл цэцэг.

ДИЗЕЛЬ дотоод шатлагат хөдөлгүүртэй машины нэр; *дизель мотор.*

ДИЗЕНТЕРИ улаан суулга.

ДИЙЗ жижиг таваг; *шаазан дийз; шилэн дийз; аяганы дийз.*

ДИЙЗЛЭХ дийзэнд хийх.

ДИЙЛГЭХ дийлэхэд хүргүүлэх.

ДИЙЛДҮҮЛЭХ дийлдэхийн үйлдүүлэх хэв.

ДИЙЛДЭХ дийлэхийн үйлдэгдэх хэв, автагдах, давагдах.

ДИЙЛДЭШГҮЙ дийлдэхийн аргагүй, давагдахын аргагүй.

ДИЙЛҮҮЛЭХ дийлэхийн үйлдүүлэх хэв, дийлэхэд хүргүүлэх.

ДИЙЛШГҮЙ хүч тэнцэшгүй, давагдашгүй.

ДИЙЛЭГДЭХ дийлэхийн үйлдэгдэх хэв.

ДИЙЛЭГДЭШГҮЙ дийлэгдэх аргагүй, хүч хүршгүй.

ДИЙЛЭНХ ихэнх, зонхи, гол төлөв, олонхи; *эр дийлэнх хонь; гурил дийлэнх ачаа; шарилж дийлэнх ургамал.*

ДИЙЛЭХ 1. ялах, давах, хүч хүрэх; *барилдаад дийлэх; байлдаад дийлэх; өргөж дийлэх; нойр дийлэх; хийж дийлэх; худалдан авч дийлэх;* 2. нэг тийшээ хэлтийх; *улаан тэмээний ачаа зөв тийшээ дийлээд байна.*

ДИЙЛЭХГҮЙ давахгүй, хүч хүрэхгүй.

ДИЙЛЭХТЭЙ дийлж чадахтай, дөнгөхтэй; *хэдий ядравч би чамайгаа дийлэхтэй.*

ДИКТАТУР дарангуйлан захирах засаг; *пролетарийн диктатур-нийт ард түмний төр болох тухай.*

ДИЛ маалинга, ургамлын үр; *цагаан дил; хар дил; дилийн тос.*

ДИНАМ цахилгаан ток гаргах машин.

ДИНБУН жундан гэдэг торго.

ДИНШИГ цанхилзуурын адил бөгөөд жижигхэн хоёр дүгрэг төмөрлөг, хооронд нь харшуулан дуугарах хөгжмийн зэвсэг.

ДИПЛОМ 1. дээд сургууль төгссөн, мөн ямар нэгэн цол зэрэг авсан хүнд олгох үнэмлэх; мэрэгжлийн диплом; 2. ямар нэгэн үзмэр буюу тэмцээнд өндөр үнэлэлт авсан хүнд шагналын журмаар олгох гэрчилгээ.

ДИПЛОМАТ 1. харь улстай харилцахын тулд буюу ямар нэг гэрээ хэлэлцээ хийхээр улсаа төлөөлсөн этгээд; *дипломат төлөөлөгч;* 2. нэг улс нөгөө улстай харилцах гадаад бодлого; *дипломат бодлого.*

ДИСПАНСЕР эмчлэн сувилаад зогсохгүй, өвчнөөс урьдчилан сэргийлэх эмнэлгийн байгууллага; *сүрьеэ өвчний диспансер.*

ДИСПЕТЧЕР галт тэрэг, усан онгоц, машина зэрэг тээврийн хөдөлгөөнийг зохицуулагч; *баазын диспетчер.*

ДИССЕРТАЦИ эрдмийн зэрэг хамгаалах зохиол; *докторын диссертаци.*

ДИЦ халуунд тэсвэртэй мөнгө мэт цайвар өнгөтэй төмөрлөг, техникт хэрэглэгдэнэ.

ДИЦДЭХ юмыг дицээр өнгөлөх түрхэх.

ДИЯАН даяан.

ДИЯАНЧ даяанч.

ДИЯАНЧЛАХ даяанчлах.

ДО хөгжмийн үндсэн долоон эгшгийн нэг.

ДОАЗ ялж дийлсний тэмдэг, жанцан ч гэнэ.

ДОВ чийгтэй нуга, намагт байх овгор товгор газар; **дов сондуул** х о р ш.; **ов дов цоохор** (энд тэнд цоохор).

ДОВГОР 1. дорвогор, товхгор; *довгор уруултай;* 2. овор, биеэ дээгүүрт боддог зантай; *тэр чинь мөн довгор зан гаргаж байна шүү.*

ДОВЖОО 1. байшингийн суурь; *чулуун довжоотой байшин;* 2. байшинд орох шат гишгүүртэй саравч бүхий бяцхан талбай; *байшингийн довжоо дээр зогсож байв.*

ДОВЖООЛОХ довжоо тавих, довжоо болгох.

ДОВОЙЛГОХ довойхын үйлдүүлэх хэв, довойход хүргүүлэх.

ДОВОЙХ довгор болох.

ДОВТЛОГО довтлох үйлийн нэр.

ДОВТЛОГЧ 1. дайрагч; *довтлогч этгээдийг няцаав;* 2. яаран сандран явагч.

ДОВТЛОХ 1. уналгаар түргэн явах, давхих; *мориор довтлох;* 2. цэрэг зэвсгийн хүчээр гэнэт халдан байлдах; *халдан довтлох;* **дайрч довтлох** х о р ш.; 3. ш и л ж с э н үйл явдлыг түргэвчлэн хийх.

ДОВТЛУУЛАХ 1. довтлохын үйлдүүлэх хэв; 2. довтлогдох..

ДОВТОЛГОО довтолгох үйлийн нэр; **соёлын довтолгоо** (соёлч боловсон байдлыг ахиулах арга хэмжээ).

ДОВТОЛГОХ довтлоход хүргүүлэх, довтлуулах, яаруулах, түргэлүүлэх; *элч довтолгох; бичиг довтолгох.*

ДОВЦОГ ов тов өндөрхөн газар; *довцог толгой.*

ДОГ юмны оройд чимэг болгон хийсэн зүйл; *тугны дог; дээрээ догтой.*

ДОГДГОЛЗОХ 1. догдолзох; 2. ш и л ж с э н доноголзох.

ДОГДГОНОХ долгин амьтны тогтворгүй ааш байдал гарган догдголзох.

ДОГДЛОСХИЙХ догдлохын хурамхан үйлдэх байдал.

ДОГДЛОХ юманд яарах тэвдэх, сочих зэрэгт бие махбод болон сэтгэл хөдлөх; *бие догдлох; сэтгэл догдлох; уулзахсан гэхээс зүрх догдолж байв.*

ДОГДЛУУЛАХ догдлохын үйлдүүлэх хэв.

ДОГДОЛГОХ доргилгох, догдлуулах.

ДОГДОЛЗОХ айх, яарах, сандрах, даарах зэрэгт бие тэсч ядан хөдлөх.

ДОГДОЛЗУУЛАХ догдолзохын үйлдүүлэх хэв.

ДОГДОР а м ь т а н цэнгэг ус, далайд орших алганы намын загас, авлаж ашиглана.

ДОГДОСХИЙХ гэнэт сочин хөдлөх, давхийх.

ДОГЖИР ш а ш и н муу үйлийг хариулах буцаах гүрмийн зан үйл, гурилаар шовх гурвалжин хэлбэр гаргаж хийсэн балин.

ДОГЖИРДОХ муу үйлийн эсрэг догжир хаях зан үйл үйлдэх.

ДОГИРОХ догь болох.

ДОГИРХОГ догь зан байдал гаргах, догиороо бардамнах.

ДОГИРХОХ догь зан гаргах.

ДОГИРХУУ догь байдалтай.

ДОГМА дээрээс таалсан гэсэн санаа, юмыг ямар ч шүүмжлэлгүй сохроор бишрэн дагах буюу хэлбэрийг баримтлах үзэл явууллага.

ДОГМАТИЗМ догмыг баримталсан сургаал.

ДОГМАТИКЧ догматизм баримтлагч.

ДОГНИУДАХ хэтэрхий догниун болох.

ДОГНИУН ухаан муутай, моншин, дүйнгэ.

ДОГНИУХАН баахан догниун.

ДОГНОГОЛЗОХ 1. морь малын толгой дээш өлөлзэх; 2. доноголзох.

ДОГНОГОР хэвийн жишээнээс том, эв хавгүй, өндөр, урт, огногор, онцгор; *догногор толгойтой; догногор хамар; догногор хад.*

ДОГНОЙЛГОХ догнойхын үйлдүүлэх хэв.

ДОГНОЙХ догногор болох, онцойх.

ДОГОЛ I тэгш, түвшин, шулуун биш, булан, мухар; *байшингийн догол; догол гудамж; догол дахь хаалга;* **булан догол** х о р ш.; **догол гаргах, догол мөр** (бичиг зохиолын доторхи дарж эхэлсэн шинэ мөр).

ДОГОЛ II малын хөлд тохиолдох нэг зүйл өвчин.

ДОГОЛГОХ доголуулах; *морио доголгох.*

ДОГОЛГУУЛАХ доголгохын үйлдүүлэх хэв.

ДОГОЛДОХ 1. догол гаргах; *доголдож өнцөг булан гаргах;* 2. ш и л ж с э н тэгш жигд биш хөдлөх, ажиллах; *цаг доголдох; зүрхний цохилт доголдох.*

ДОГОЛДУУЛАХ доголдохын үйлдүүлэх хэв.

ДОГОЛОН нэг хөлд гэм согогтой учраас явахдаа түүнийг өргөж доголдог; *доголон морь; доголон хүнд таяг түшиг; доголон шаазгай дов тойрох* о н ь с о г о **доголон ханчир** а м ь т а н (бие хар, улаан махан халзтай, дэвхээ газар оршдог нэгэн зүйл шувуу).

ДОГОЛОХ нэг хөл гэм согогтой учир тэгш явж чадахгүй болох; *хөл нь доголжээ.*

ДОГОЛУУЛАХ доголохын үйлдүүлэх хэв, доголгох.

ДОГОНЦООХ 1. догонцох; 2. догонцоход хүргүүлэх, догонцуулах.

ДОГОНЦОХ 1. догоцох; *догонцож тоглох;* 2. түвшин бус, тогтворгүй байдалтай болох; *сэтгэл догонцох; үйл явдал догонцох; ширээ догонцох.*

ДОГОНЦУУЛАХ догоцохын үйлдүүлэх хэв, догонцоох.

ДОГОЦОХ нэг хөл өргөж нөгөө хөлөөр харайлах; *догоцож наадах; догоцож уралдах.*

ДОГШДОХ хэтэрхий догшин болох; *энэ төмөр догшдоод тохиромжгүй байна; миний бор морь догшдоод унах аргагүй болжээ; догшдоод амсах аргагүй болсон айраг.*

ДОГШДУУЛАХ догшдохын үйлдүүлэх хэв.

ДОГШИН 1. амьтны зан байдал номхон даруу биш хатан, ширүүн харгис; *догшин ууртай хүн; эмнэг догшин морь;* 2. юмны чанар, хат, хэтэрхий чанга; *ган төмөр хэдий догшин боловч галд заавал уярдаг;* 3. юмны ааг чадал хатуу, их; *догшин амт; догшин архи; догшин салхи.*

ДОГШРОХ юмны улам догшин болох, нэмэгдэх, ширүүсэх; *морь догшрох; салхи догшрох; айраг догшрох.*

ДОГШРУУЛАХ догшрохын үйлдүүлэх хэв, догшин болгох.

ДОГЬ олныг өнгөрүүлж хашир болсон нь; *догь амьтан; догь толгой.*

ДОГЬДОХ догь байдал нь хэтрэх, дэндэх.

ДОГЬТОХ догь зан байдал гаргах, догь царай гаргах.

ДОГЬШРОХ хашир догь байдалтай болох; *догьширсон амьтан.*

ДОДИГОР ш о о д с о н өчүүхэн байтлаа биеэ би гэж тоосон зан байдал; *додигор эр; чиний додигор занг хэн тоох юм бэ?*

ДОДИЙЛГОХ додийхын үйлдүүлэх хэв, додийход хүргүүлэх.

ДОДИЙХ додигор болох.

ДОДОМДЛОГО додомдох үйлийн нэр; *додомдлого сайтай бол алзахгүй.*

ДОДОМДОХ 1. засч өөд нь татах; *додомдож байгаад ургуулж чаджээ;* 2. тэтгэж засч өөд нь татах; *додомдож байгаад мал хийгээд авлаа.*

ДОДОМДУУЛАХ додомдохын үйлдүүлэх хэв.

ДОЁГО: доёго доёго хийх доёгор юмны үргэлжлэн хөдлөх.

ДОЁГОНОХ доёгор юмны доёго доёго хийх.

ДОЁГОНУУЛАХ доёгонохын үйлдүүлэх хэв.

ДОЁГОР нарийн урт болоод нэг тийшээ баахан муруйдуу; *хэнгэргийн дохиур мэт доёгор; доёгор уурга.*

ДОЁЛЗОХ доёгор юмны доёс доёс хийх.

ДОЁЛЗУУЛАХ доёлзохын үйлдүүлэх хэв.

ДОЁС: доёс доёс хийх доёгор юмны байн байн хөдлөх

ДОЁЫЛГОХ доёыхын үйлдүүлэх хэв, доёгор болгох.

ДОЁЫХ доёгор болох; *доёысон өндөр мод.*

ДОЙ ш а ш и н гай зэтгэрийг арилгах засах зан үйлийн нэр.

ДОКТОР 1. эмч; 2. эрдмийн дээд зэрэг.

ДОКТОРАНТУР докторын зэрэг хамгаалах эрдэмтдийн бэлтгэх эрдэм шинжилгээний газар.

ДОЛ I модны дурс; *бургасны дол.*

ДОЛ II хал, **хал дол** х о р ш .; *хал үзэж хашир таньсан; долоо доншиж дол цохьсон* х у у ч ; **дол цохьчихсон амьтан** (хал дол үзэж хашир догь болсон).

ДОЛГИЛОХ 1. долгион гарч хөдлөх, байн байн долгих; *салхи ширүүсч далайн ус хүчтэй долгилов;* 2. ш и л ж с э н хөдлөх, тэмүүлэх, догдлох. булгилах; *сэтгэл долгилох; зүрх долгилох.*

ДОЛГИЛУУЛАХ долгилохын үйлдүүлэх хэв. долгилоход хүргүүлэх.

ДОЛГИН 1. омголон, догшивтор; *долгин аашгай морь;* 2. ш и л ж с э н хөнгөн, болгоомжгүй, түргэч; *долгин зантай хүн.*

ДОЛГИО долгион.

ДОЛГИОЛОХ долгилох, долгио гаргах.

ДОЛГИОН 1. усны дээд өнгөн тал, савлан хөдлөхөд гарах давлагаа; *далайн долгион;* 2. физикийн орчин дотор үүсэх савлах хөдөлгөөн; *дууны долгион; агаарын долгион; гэрлийн долгион.*

ДОЛГИОТОХ долгио гарах.

ДОЛГИРХОХ долгин зан гаргах.

ДОЛГИСОХ 1. бие эвэрлэн, мах таталдаж тачаадах; *бие долгисох;* 2. сэтгэл үймчин хөдлөх: *сэтгэл долгисох*

ДОЛГИХ долгилох, долгисох.

ДОЛГОНЦОГ 1. идэх уухад ховдог; 2. сувдаг шунахай.

ДОЛГОНЦОГДОХ хэтэрхий долгонцог болох.

ДОЛГОНЦОГЛОХ долгонцог байдал гаргах, шунахайрах, сувдаграх.

ДОЛГОНЦОГЛУУЛАХ долгонцоглохын үйлдүүлэх хэв.

ДОЛГОНЦОГРОХ долгонцог болох, шунах,

ДОЛГОНЦОГТОХ долгонцог зан гаргах.

ДОЛДГОНОХ хөнгөмсөг ааш авир үзүүлэн бялдууч байдал гаргах; **дэлдгэнэх долдгонох** х о р ш ..

ДОЛДГОНУУЛАХ долдгонохын үйлдүүлэх хэв.

ДОЛДГОНУУР зусарч, бялдууч, зулгуйч; *долдгонуур зан гаргах.*

ДОЛДОЙ зусар зулгуйч; *долдой хүн.*

ДОЛДОЙДОХ I хэтэрхий долдой болох.

ДОЛДОЙДОХ II аливаа бүтээх үйл явдлыг ямар нэгэн юманд итгэж найдах, тулгуурлаж дулдуйдах гэнэ.; *олон түмний хүчинд долдойдох.*

ДОЛДОЙЛОХ зусардах, бялдуучлах, долдой зан гаргах; *тэгэлгүй яах вэ, тэгэлгүй яах вэ гэж долдойлж байжээ.*

ДОЛДОЙЛУУЛАХ долдойлохын үйлдүүлэх хэв.

ДОЛДОЙРХОХ долдой зан байдал гаргах.

ДОЛДОЙЧ ямагт долдойлон явдаг хүн.

ДОЛДУГААР дэс дугаарын *тоо; долдугаар сар.*

ДОЛЖГОНОХ 1. долир юмны үргэлжлэн должго должго хийх; 2. бялдуучлах, долигонох.

ДОЛЖИЛЗОХ 1. долир солжир юмны байн байн должис должис хийх; 2. долигонох, зулгуйдаж явах.

ДОЛЖИР солжир, долир; *должир эвэр; должир нүд.*

ДОЛИГОНОХ I долир амьтны долиго долиго хийж хөдлөх.

ДОЛИГОНОХ II зусарч бялдууч зан байдал гаргах.

ДОЛИГОНУУЛАХ долигонохын үйлдүүлэх хэв.

ДОЛИГОНУУР зусарч, зулгуйч зантай; *долигонуур хүний зан тийм байдаг.*

ДОЛИЙЛГОХ долийхын үйлдүүлэх хэв.

ДОЛИЙХ долир болох; *долийж харах.*

ДОЛИЛЗОХ долиу долир юмны дольс дольс хийж хөдлөх.

ДОЛИЛЗУУЛАХ долилзохын үйлдүүлэх хэв.

ДОЛИНГОР догь, хашир болсон; *хал дол үзэж долингор болсон хүн.*

ДОЛИНГОРДОХ долингор нь нэндэх хэтрэх.

ДОЛИНГОРОХ долингор болох.

ДОЛИНГОРТОХ долингор байдал гаргах.

ДОЛИНГОРШИХ долингорын шинжтэй болох.

ДОЛИР 1. нүдний өвчин, хоёр хүүхэн хараа нэг цэгт биш; *долир нүд;* 2. солжир; *долир эвэртэй үхэр.*

ДОЛИУ долир, далиу.

ДОЛЛАР Америкийн нэгдсэн улс болон бусад зарим орны мөнгөний нэгж; *долларын тоцоо.*

ДОЛЛОГО 1. өнгөлөн гүрхэх маажин тос; *доллого будаг;* 2. юманд өнгөнцөр тавьж зулах юм; *доллого хөвөн.*

ДОЛОЛГОХ юмны дээгүүр ямар нэгэн юм өнгөнцөр нимгэн түрхэх, зулах; *ширдсэн будсан юмны дээгүүр будаг дололгох; дээлийн хажилгад хөвөн дололгох.*

ДОЛОНО ургамал долоогонын нэгэн зүйл бут мод.

ДОЛОО (Н) 1. тооны нэр, зургаа дээр нэгийг нэмэх нь; *хоёр долоо хоног; долоон долоо дөчин ес болно;* 2. долооны өдөр; *арван нэгдүгээр сарын долооны өдөр баяр хийнэ;* **долоон өвгөн, долоон бурхан** зурхай (умардад орших долоон их од); **долоо хоног** (долоон өдөр шөнөтэй тэнцүү хоног тооллын нэгж); **долоон гараг** (хэд хэдэн янзаар нэрлэж тоолдог: а. Адьяа, Сумьяа, Ангараг, Буд, Бархасвадь, Сугарь, Саньчир; б. Ням, Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан, Бямба; в. Наран одон, Саран одон, Гал одон, Усан одон, Модон одон, Алтан одон, Шороо одон; г. Наран, Саран, Улаан нүдэн, Үлэмж, Гадсан, Цолмон, Ховдог эмгэн); **долоон голтой (зовлонд маш тэсвэртэй, зовлон их даадаг; тэр чинь долоон голтой амьтан);** **долоон ходоодтой** (хэтэрхий ховдог); **долоон уулын цаагуур, дов шороон доогуур** (холын хол, далдын далд, бүү үзэгд); **доройтохын долоон хамсаа** (доройтох шалтгаан олшрох); **долоо дордож, найм сэхэх** (ямагт муу байхгүй).

ДОЛООВОР I хүний гарын хоёрдугаар буюу заах хуруу; *долоовор хуруу.*

ДОЛООВОР II уруулд гэнэт цэврүүтэн гарах яр, хомхой ч гэнэ; *долоовор яр.*

ДОЛООВОР III мараа, шорвог; *долоовортой газар.*

ДОЛООВОРДОХ долоовор хуруугаар үйлдэх.

ДОЛООВОРТОХ уруул дээр долоовор яр гарах.

ДОЛООГОНО ургамал тэргүүлэгч цэцгийн язгуурын мөчиртөө өргөстэй, хөрөөний ир мэт навчтай, жижиг бөөрөнхий жимсгэнэтэй бут мод; төрөл зүйл олон, зарим жимсгэнийг иддэг, цэцэрлэг болгож тарина; үүний мод, жимсгэнэ аль алий нь долоогоно гэдэг.

ДОЛООГУУР: долоогуур үлд уруулын дотор гарах үлхий яр.

ДОЛООД тус бүр долоо.

ДОЛООДОС долоосон юм; *нохойн долоодос.*

ДОЛООЛГОХ 1. долоохын үйлдүүлэх хэв, *долоохуд хүргүүлэх* 2. *долоолгох; будаг долоолгох;* **чулуу долоолгох** (нимгэн хавтгай чулууг усны дээгүүр шидэж дүүлүүлэн үсэргэх): **жаварт долоолгох** (хүйтэнд бага зэрэг хайрагдан хөлдөх).

ДОЛООНТАА долоон удаа.

ДОЛООХ хэлийг хүргэн шүргэх, хэлээр хамах, арчих; *хав гары нь долоов; үнээ, тугалаа долоох; үхэр долоочихсон мэт гөлийж орхижээ;* **халуун чулуу долоох** (зүйл бүрийн бэрхшээл давж өнгөрүүлэх); **хомхой долоох** уруул дээр цөврүү яр гарах).

ДОЛОР хал, хашир.

ДОЛОРШИХ долор шинжтэй болох.

ДОЛРОХ I 1. модны дол хялбар хуурам болох; *мод долрох;* 2. шилжсэн ямар нэгэн юм, модны дол мэт нимгэн нимгэн ховхрон хуурах.

ДОЛРОХ II хал хашир үзэж дол цохих, догишрох; *элдвийгээ үзэж долорсон хүн дээ, тэр гуай.*

ДОЛУУЛ хам тоо; *долуул явав; долуул бэлэн бий.*

ДОЛШРОХ олон зүйлийг өнгөрөөж дадах, сурамгай болох, долрох; *олон оймс элээсний хувьд долшрох нь зөв.*

ДОМ I у р г а м а л дурс хар, навч том, чанар нарийн зөөлөн, сийлэх цоолборлоход тохиромжтой нэгэн зүйл мод.

ДОМ II у р г а м а л далдуу II.

ДОМ III х у у ч и р с а н эмчлэх засах арга; *эм дом; арга дом; дом засал; хар дом.*

ДОМ IV домбо.

ДОМ V шарын шашны ёсны чойрын сургууль төгсгөхөд хийх баярын хурим; *домын дамжаа барих; дом тавих; дом хийх.*

ДОМБО шингэн зүйл агуулах цоргогүй хараатай сав; мод төмөрлөгөөр хийнэ; *цайны домбо; домботой цай;* **домбон үрэл** (машинад хэрэглэх зууван гонзгой хэлбэртэй үрэл).

ДОМБОР шанаган хэлбэртэй 3—4 чавхдастай хөгжмийн зэвсэг.

ДОМКРАТ өргүүр, *машины домкрат.*

ДОМНОЛГО домнох үйлийн нэр; *домнолго хийх;* **эмнэлэг домнолго** х о р ш . .

ДОМНОХ 1. х у у ч и р с а н өвчнийг анагаахаар арга дом хийх; 2. ш и л ж с э н юмыг орнэр болгох, хийсэн болох, муу хийх; *үзэх гэж домнооод өнгөрлөө.*

ДОМНУУЛАХ домнохын үйлдүүлэх хэв, дом хийлгэх.

ДОМОГ 1. эртнээс нааш амаар үе улиран уламжлагдаж ирсэн түүхт үйл явдал, ер бусын үзэгдэл юмны тухай үлгэр яриа; *ийм домогтой юм ...;* **үлгэр домог** х о р ш . ; 2. ш и л ж с э н байн байн ярьдаг зүйл, улиг болсон зүйл; **улиг домог** х о р ш . : *улиг домог болох.*

ДОМОГЛОХ 1. үгээр доогхийн уйдуулах; 2. юмыг хийсэн дүр байдал гаргаж оролдох; *ажлаа домоглосон болж байна.*

ДОМОГТ домог дотор, улигт; *домогт гардаг.*

ДОМОГТОЙ домог бүхий; *тийм домогтой юм.*

ДОМТОХ ам гэмтэх өвчин тусах; *ам домтох.*

ДОМТИ донти.

ДОМЧ арга дом хийгч; **эмч домч** х о р ш . .

ДОМЧЛОХ домч хүний арга дом хийх; **эмчлэх домчлох** х о р ш . .

ДОН I 1. ш а ш и н ад хий юм; *дон нөхцөх; дон шүглэх;* 2. хэт дур хүсэлтэй болсон нь; *архины донтой болжээ; айл хэсэхийн дон болсон амьтан.*

ДОН II: **дон дон хийх** 1. хатуувтар юмны дэлдэгдсэнээс гарах чимээ; *дон дон хийх чимээ, юуны чимээ вэ?;* 2. ш о о д с о н хүний эв дүйгүй дургүй хүрэм ярих; *битгий дон дон хийгээд бай.*

ДОНБО домбо; **морин домбо** (том домбо).

ДОНГИО тэнэг, дүйнгэ; *дуугүй явбал донгио гэх, дуугараад явбал чалчаа гэх* з ү й р .

ДОНГИОДОХ дэндүү донгио болох.

ДОНГИОДУУ дүйнгэ, мангуу.

ДОНГИОРОХ донгио болох.

ДОНГИОТОХ донгио байдал гаргах.

ДОНГИОХОН баахан донгио, арай донгио.

ДОНГО: донго эм нүүр угаадаг нэг зүйл эм

ДОНГОДОХ I шувууны дуугарах; *хөвчийн өндөр ууланд хөхөө шувуу донгодно* а р д ы н д у у .

ДОНГОДОХ II зэмлэн буруушаах, бурууг зааж зэмлэх; *нийтийн хурал дээр донгодов; тушаалаар донгодох.*

ДОНГОДУУЛАХ 1. донгодохын үйлдүүлэх хэв; 2. зэмлэл донгодлого хүлээх.

ДОНГОСОХ дэмий чалчин ярих; *дэмий донгосох хэрэггүй.*

ДОНГОСУУЛАХ донгосохын үйлдүүлэх хэв.

ДОННИУН догниун.

ДОНОГОЛЗОХ санаа сэтгэл түвшин тогтворгүй, юм бодож үймчих; *сэтгэл доноголзох.*

ДОНОЛЗОХ доноголзох; *сэтгэл донолзох.*

ДОНРОЙ чанар хатуу биш, өнгө улбар шар нэгэн зүйл чулуулаг; эмд ба түрхэх зурахад хэрэглэдэг.

ДОНСЛОХ 1. доргих дэнслэх; *тэрэг донслох; бие донслох;* 2. тувшин тогтворгүй болох; *сэтгэл донслох; зүрх донслох.*

ДОНСЛУУЛАХ донслохын үйлдүүлэх хэв.

ДОНСОЛГОО доргио, дэгэн догон ихтэй; *донсолгоотой газар; машиныи донсолгоо.*

ДОНСОЛГОХ донслоход хүргүүлэх, донслуулах.

ДОНТИ баавгайн цөс; *баавгайн донти.*

ДОНТОЙ дон нөхцсөн; *донтой өвчин.*

ДОНТОХ дон нөхцөж дэмий ярих, дэмий донгосох.

ДОНХГОНОХ донхгор юмны донхго хонхго хөдлөх.

ДОНХГОР дэнхгэр, догногор, дунхгар; *донхгор малгай; донхгор гэр.*

ДОНХОЙЛГОХ донхойхын үйлдүүлэх хэв; донхгор болгох.

ДОНХОЙХ донхгор болох.

ДОНХОЛЗОХ донхгор юмны донхос донхос хөдлөх.

ДОНХОР донхгор.

ДОНШИХ 1. хэсүүчлэх, тэнэх: *долоог доншисон догь толгой;* 2. дон дон хийж байн байн нуршин хэлэлцэх.

ДОНШМОЛ доншооч, тэнэмхий; *доншмол хүн.*

ДОНШООЧ 1. дэмий хэсэмтгий зантай; *доншооч нь хэтэрсэн амьтан;* 2. эрээ цээргүй дэмий ярьдаг; *дэндүү доншооч шүү.*

ДОНШООЧДОХ хэтэрхий доншооч болох.

ДОНШУУРЧ доншуучилж явдаг хүн.

ДОНШУУРЧДАХ хэтэрхий доншуурч болох.

ДОНШУУРЧЛАХ доншуучлах.

ДОНШУУЧЛАХ дэмий айл хэсүүчлэх, тэнэж тойрч явах; *хэдэн долоо хоног доншуучилж явав гэнэ.*

ДОНШУУЧЛУУЛАХ доншуучлахын үйлдүүлэх хэв.

ДОО жад хутга мэтийн ишний үзүүрт углах шумгай төмөрлөг; *жадны доо; хутганы доо.*

ДООГ даажин, тоглоом, наадам; *доог хийх; элэг доог болгох.*

ДООГЛОХ бүсдыг үл тоомсорлон наадам тоглоом болгон үзэх, даажигнах.

ДООГЛУУЛАХ 1. дооглохын үйлдүүлэх хэв; 2. дооглогдох.

ДООГУУР 1. дээгүүрийн эсрэг утга; доод талаар, доод талд, дор; *орон доогуур орох; бүсээ доогуур бүслэх; биеэ доогуур үзэх; усан доогуур явдаг онгоц;* 2. чигээр биш, эгц биш; *доогуур харах; доогуур харц;* 3. шилжсэн эцэст, хойно, сүүлд; *бариад доогуур орох;* 4. доод тушаалын; *доогуур хумүүстэй нь ярилцах.*

ДООГУУРДАХ дэндүү доогуур болох; *бүс чинь доогуурджээ.*

ДООГУУРДУУЛАХ доогуурдахын үйлдүүлэх хэв.

ДООГУУРЛАХ юмыг доогуур болгон үзэх.

ДООГУУРТАХ улам доогуур болох.

ДООГУУРХАН арай доогуур.

ДООД дээд гэдгийн эсрэг утга; 1. босоо юмны газрын зүг гийших; *модны доод үзүүр;* 2. юмны адаг сүүл буюу хойтох; *доод дэвтэр; доод тал;* 3. эрхэм дээд биш; *доод төрлөхтөн;* 4. эхэлбэртэй буюу зэрэг дэвтэй юмны удаалах буюу адаг этгээд; *би ахын доод талд суув;* 5. үелсэн давхарласан юмны хамгийн дээдэхээс дооших; *доод давхар;* **доодын хагас сар** (сар бүрийн 23-ны орчин үеийн заримдаг сар).

ДООЖ дээж гэдгийн эсрэг утга; *дээж нь биш ч гэсэн доож нь лав биш.*

ДООЖГҮЙ жудаггүй, яс чанар муутай, үзэмжгүй; *доожгүй зан гаргах хэрэг байдаггүй; доожгүй царайтай явна билээ; доожгүй эд харагдаж байдаг шүү.*

ДООЖИГНОХ доожин болгох, адагт үзэж тоглоом хийх, хэтэрхий доромжлон үзэх.

ДООЖИН юмны адагт байгаа; *доожин юм; доожин мал;* **доог доожин** хорш..

ДООЖОО 1. үзэмж, янз; *доожоо муутай;* 2. зан, байдал.

ДООЖООГҮЙ 1. үзэмж муутай, янз муутай; 2. зан байдал муутай; *доожоогүй хүн.*

ДООШ (ОО) 1. дээшийн эсрэг үг, доод тал руу; *доошоо харах; доош нь тавих; дээрээс доош нь буулгах;* 2. ямар нэгэн тооноос цөөн,

бага; *таваас доош насны;* **доошоо орох** (нас тэнцэхгүй хүүхэд багачуудтай шалиглах, уруу татах).

ДООШДОХ нэндүү доош болох.

ДООШДУУЛАХ доошдохын үйлдүүлэх хэв.

ДООШЛОХ 1. доошоо болох, нам болох; *дээрээс доошлох;* 2. уруудах, урагшаа явах; *голоор доошилж явлаа;* 3. намжих, дарагдах; *өвчтөний халуун нь доошилсон байв;* 4. буурах, доройтох; *доошилж яваа хүн дээ.*

ДООШЛУУЛАХ доошлохын үйлдүүлэх хэв.

ДОР 1. дээр гэдгийн эсрэг утга; *газар дор базар эрх оньсго; ширээний бүтээлэг дор; удирдлагын дор; захиргааны дор; эрхийн дор; хамар дор ам;* 2. нам; *дор газар; дор дуугаар дуугарах;* 3. дэс дараагаар хойно, сүүлд; *дор суух; ахлах дарга нарын дор жагсав; хурдны морь дор давхив;* **дор орох** (ядуу дорой болох); 4. дараа, сүүлд, хойно, эцэст; *дор хавсаргав; дор дүрдсан; дор тодорхойлох;* 5. шилжсэн чанараар дутуу, муу; *энэ эд нөгөөдөхөөсөө хол дор юм;* 6. даруй, ирсэн дор; *үнэсан дороо ухаарав; харсан дороо дурлав;* **дор дороо** (тус тус, тус бүр); **дороо!** (тэр газартаа, дороо зогс!, дороо бай!, дороо алхаад!); **дор үзэх** (басамжлах, дээрэлхийлэх).

ДОРВИ чадвар, чинээ; **дорви муутай** (чадвар муутай).

ДОРВИГҮЙ чадвар чинээ дорой, буурай.

ДОРВИЛОГ дорвитой, чадалтай; *дорвилог хөдлөх; дорвилог нэгдэл.*

ДОРВИРХОХ дорви гаргах, үзүүлэх.

ДОРВИТОЙ 1. чадвартай, чадалтай; *дорвитой зохиолч;* 2. сайн чанарын; *дорвитой эд;* 3. том биетэй, тэнхээтэй; *дорвитой шар.*

ДОРВИТОЙХОН нилээд дорвитой.

ДОРВОГО I 1. жижигхэн тогоо; 2. шингэн зүйл агуулж биедээ зүүж явах жижиг сав,

ДОРВОГО II: дорвого дорвого хийх доровгор юмны үргэлжлэн хөдлөх.

ДОРВОГОНОХ дорвогор юмны дорвого дорвого хөдлөх.

ДОРВОГОР барвагар, цорвогор, довгор; *дорвогор уруултай; дорвогор шүд.*

ДОРВОЙЛГОХ дорвойхын үйлдүүлэх хэв, дорвогор болгох.

ДОРВОЙХ 1. дорвогор болох; 2. шилжсэн хүний санаа сэтгэл гутарч бодлого болох.

ДОРВОЛЗОХ дорвогор юмны дорвос дорвос хөдлөх.

ДОРВОЛЗУУЛАХ дорволзохын үйлдүүлэх хэв.

ДОРВОС: дорвос дорвос хийх дорвогор юмны байн байн хөдлөх.

ДОРГИЛГО доргих үйлийн нэр.

ДОРГИЛОХ байн байн доргих.

ДОРГИЛТ доргио; *доргилт ихтэй.*

ДОРГИЛУУР ямар нэгэн багаж хэрэгслийн тогтмол хөдөлгөөнийг үүсгэгч хэсэг; юм шигших, холих, ялгахад хэрэглэнэ; *нарийн доргилуур.*

ДОРГИО (Н) доргих хөдөлгөөн, нөргөөн; *доргио ихтэй.*

ДОРГИОХ доргихын үйлдүүлэх хэв, доргиулах.

ДОРГИУЛАХ доргихын үйлдүүлэх хэв.

ДОРГИУР авианы хэлбэлзлийг үүсгэн хялбар доргих уян хатан зүйлээр хийсэн юм; *утасны харилцуурын доргиур.*

ДОРГИХ ямар нэгэн хөдөлгөөний хүчнээс юм нөргөлж сэгсэрхийлэн хөдлөх; *бие доргих; газар доргих; их буугийн дуунаас газар доргих шиг болов; бага чулуугаар их чулуу доргиулах* хүүч үг.

ДОРГО амьтан суусрын язгуурын хөхөөр өсгөх араатан, ойд оршдог, өвөл ичнэ.

ДОРГОМЖ зан байдал даруу, дорой байдалтай; *доргомж хүн;* доромж ч гэнэ.

ДОРГОМЖХОН баахан доргомж.

ДОРГОМЖТОХ үр тариа ургаж өсөвч өнгө муу, цэцэглэхгүй болох; *тариа торгомжтох.*

ДОРД доод.

ДОРДГОР дардгар, дорсгор, дорвогор; *дордгор уруул.*

ДОРДОЙЛГОХ дордойхын үйлдүүлэх хэв.

ДОРДОЙХ I дордгор болох; *арьс дордойж хатав.*

ДОРДОЙХ II хорсож хар санах, ая эв эвдэрч муудах; *ам дордойх: элэг дордойх.*

ДОРДОЙХГҮЙ хар хор хадгалахгүй, *ам дордойвч элэг дордойхгүй* х у у ч.

ДОРДООХ дордохын үйлдүүлэх хэв, дор болгох.

ДОРДОХ намдах, хэтэрхий дор болох; *цонх нь дорджээ; ташааны нь товч дордсон дээл.*

ДОРДУУЛАХ дордохын үйлдүүлэх хэв.

ДОРИУН нилээд сайн; зэгсэн, овоо, бузгай сайн; *дориун хүн: дориун хийцтэй эд.*

ДОРНО зүүн, нар гарах зүг; *Дорно зүгээс наран мандлаа* д у у; **дорно өмнө** (зүүн өмнө); **дорно умар** (зүүн хойт); **дорно дахин** (дорно зүгийнхэн; *дорно дахины судлал; дорно дахиныг судлагч*).

ДОРНОД дорно зүг, дорно зүгт байгаа; *Дорнод аймаг; дорнод хязгаар; дорнодын тал газар.*

ДОРОГШ дээш гэдэгтэй эсрэгцэлдсэн утга, доош; *хөдөлмөрийн бүтээмжийг үүнээс дорогш болгож болохгүй.*

ДОРОГШЛОХ доошлох.

ДОРОГШЛУУЛАХ дорогшлохын үйлдүүлэх хэв.

ДОРОЙ сул, буурай, ядуу; *сул дорой; дорой буурай; дорой байдал.*

ДОРОЙТЛОГО дойтол.

ДОРОЙТОЛ дойтох үйлийн нэр, буурал; **насны дойтол** (нас их болж бие махбод ядрах).

ДОРОЙТОХ дорой болох, муудах; *нас дээр гарч бие нь дойтов: архи дарс ууж үйл ажил нь дойтож яваа ажээ; дойтохоод ойтох* х у у ч.

ДОРОЙТУУЛАХ дойтохын үйлдүүлэх хэв.

ДОРОМЖ даруу, номхон, дорой; *доромж зантай хүн; даруу доромж хүүхэд.*

ДОРОМЖЛОЛ доромжлох үйлийн нэр; **дарлал доромжлол** х о р ш . .

ДОРОМЖЛОХ басамжлах, дээрэлхэх дарлах; *дайрч доромжилж яаж болох вэ!: басамжлан доромжлох; тэгж доромжилсон явдалд их л дургүйцэв.*

ДОРОМЖЛУУЛАХ 1. доромжлохын үйлдүүлэх хэв; 2. доромжлогдох.

ДОРСГОЙ шүд гадагш цойж илүү гарсан; *дорсгой шүдтэй; самны шүд дорсгой болжээ.*

ДОРСГОНОХ дорсгой юмны дорсго дорсго хөдлөх.

ДОРСГОНУУЛАХ дорсгонохын үйлдүүлэх хэв.

ДОРСГОР дорсгой; *дорсгор шүд.*

ДОРСГОХ дортоох, дорсуулах.

ДОРСГУУЛАХ дорсгохын үйлдүүлэх хэв.

ДОРСОГО: дорсого дорсого хийх дорсгор юмны үргэлжлэн хөдлөх.

ДОРСОЙЛГОХ дорсойхын үйлдүүлэх хэв, дорсойход хүргүүлэх.

ДОРСОЙХ дорсгой болох; *бодонгийн соёо дорсойж байв; дорсойсон шүдтэй.*

ДОРСОЛЗОХ дорсгор юмны дорсос дорсос хөдлөх

ДОРСООХ дор болгох, дортгох.

ДОРСОС: дорсос дорсос хийх дорсгор юмны байн байн хөдлөх.

ДОРСОХ дор болох, дортох.

ДОРСУУЛАХ дорсохын үйлдүүлэх хэв, дортуулах.

ДОРТГОХ дордуулах; *хамаагүй эм ууж байж биеэ дортгов.*

ДОРТООХ дортоход хүргүүлэх; дортуулах.

ДОРТОХ улмаар дор болох, нам болох; *урьдахаасаа дортох.*

ДОРТУУЛАХ дортохын үйлдүүлэх хэв,

ДОРХИ дор, хойнох; *газар дорхи баялаг: дорхи зүйлийг үз.*

ДОРШООХ буцдыг хөнгөлөн үзэх, доодод үзэх, эс тоомсорлох; *чи намайг доршоож байна уу.*

ДОТАЦИ тэтгэлэг.

ДОТНО I гадна гэдгийн эсрэг утга; дотор, дотоод; *гэрийн дотно; гадна дотнын хүн.*

ДОТНО II найз, элэгсэг, ойрын; *дотнын нөхөр: дотно байх.*

ДОТНОЛОГДОХ дотнолохын үйлдэгдэх хэв.

ДОТНОЛОХ дотночлох. **ДОТНОЛУУЛАХ** 1. дотнолохын үйлдүүлэх хэв; 2. дотнологдох. **ДОТНОЧЛОХ** бусдаас илүү элэгсэг найртай үзэх; *их л дотночлон ярив.* **ДОТНОЧЛУУЛАХ** 1. дотночлохын үйлдүүлэх хэв; 2. дотночлогдох. **ДОТОГШ** гадагшийн эсрэг утга; дотор тал руу; *дотогшоо харах; дотогш зогсох; дотогшоо тахир.* **ДОТОГШДОХ** хэтэрхий дотогш болох; *энэ зураас чинь хэтэрхий дотогшидсон байна.* **ДОТОГШДУУЛАХ** дотогшдохын үйлдүүлэх хэв. **ДОТОГШЛОХ** дотогш болох; *хотын төв руу дотогшилж явав.* **ДОТОГШЛУУЛАХ** дотогшлохын үйлдүүлэх хэв. **ДОТОГШЛУУР** дотогш болгох юм; *дотогшлуур булчин.*

ДОТООД 1. гадаад гэдгийн эсрэг санаа: **дотоод энгэр** (хувцасны гадаад энгэрийн дотуур оруулан өмсөх энгэр); **дотоод хормой** (дээлийн дотоод энгэрийн доод хэсэг); **дотоод гогцоо** (малгайны оройн дотор хадаж барих оосор); 2. улсын доторхи; *дотоод явдлын яам; дотоодын хэрэгцээнд зарцуулах; дотоод хэрэгт оролцох; дотоод бодлого; дотоодын нөөц;* ☆ **дотоод монгол** (өвөр монгол).

ДОТООЖ эмэгтэйчүүдийн дотуур өмсөх хувцас; *дотоожийг долоо хоног оёв* з ү й р.

ДОТОР гадна, гадар гэдгийн эсрэг санаа; 1. дотоодсд; *гэрийн дотор: усан дотор; модон дотор; гай газар дороос, гахай модон дотроос* з ү й р; 2. юмны дотоод тал, дотоод этгээд; *тогооны дотор; дээлийн дотор; хамбан гадартай халиун дотортой* а р д ы н д у у; *аяганы дотор;* 3. дотор эрхтэн, гэдэс дотор; **дотор өвх** (дотоод эрхтний өвх); **дотор мах** (гэдэс); **дотор базлах** (гэдэс базлах адил өвдөх): **дотор муудах** (гэдэс өвдөж зохисгүй болох); **дотор муутах** (гэдэс, дотоод эрхтэн муу болох); **дотор өвдөх** (гэдэс өвдөх): **дотор зайлагдах** (унаа юманд ширүүн явснаас гэдэс өвдөх); **дотор хуржигнох** (гэдэс дуугарах); **дотор мушгилах** (дотор базлах); **дотор өвчин** (гэдэс, цээжний хөндийн өвчин); **дотрын тасаг** (дотор өвчнийг анагаан засах тасаг); **дотрын эмч** (дотор өвчнийг анагаахад мэрэгжсэн эмч); **дотор им** амьтны уураг төмс ил бус; *дотор имтэй хурга);* **дотор гових** (өлсгөлөнд дотор тэсэхгүй болох); 4. ш и л ж с э н сэтгэл, санаа, бодлого; **хар дотортой, хөө дотортой** (муухай санаатай); **хүйтэн дотортой** (нинжийн сэтгэлгүй): **дотор бухимдах** (уур хилэн ихэд хөдөлж сэтгэл үймрэх); **дотор цухалдах** (дотор бухимдах): **дотор агсах** (уур хилэн бадарч тэсч ядан байх); **дотор саруул болох** (дотор уужрах); **дотор уужрах** (уур хилэн намдах); **муухай дотортой** (муу санаатай); **дотроо санах** (ухаандаа тогтоон бодох); **дотор өвдөх** (өр өвдөх); **хүний эрээн дотроо, могойн эрээн гаднаа** х у у ч (хүний хорлол далд, могойн хорлол ил); 5. дотуур; *дотор хувцас; дотор цамц;* 6. зууraa, хоорондоо, дунд; *гэрийн хэрэг гэр дотроо* х у у ч; *бид дотроо маргалдав; тэр хулгайч бидний дотор байгаагаас зайлахгүй;* 7. хугацаанд; *нэг сарын дотор багтааж гүйцэтгэх хэрэгтэй; долоо хоногийн дотор дуусгах ёстой ажил;* ☆ **дотор дэгээ** (бөхийн мэх); **дотор газар** (хятад нутаг); **дотор хүн** (хятад хүн).

ДОТОРЛОХ юманд дотор хийх, дотортой болгох; *дээл доторлох; төмрөөр доторлох.*

ДОТОРЛУУЛАХ доторлохын үйлдүүлэх хэв.

ДОТОРХИ дотор буй; *гэр доторхи юм сарниулсан байна.*

ДОТУУР дотоод, доторхи; *дотуур хувцас; дотуур бүрээс;* **дотуур дэгээ** (хөлөө нөгөө этгээдийн хөлийн дотуур оруулан ороож гэдрэг унагаах бөхийн мэх); **дотуур тамир** (хувийн хэргийг бусдынхаас урьдал болгож биеэ болох; *дотуур тамиртай хүн).*

ДОТУУРДАХ хэтэрхий дотуур болох.

ДОТУУРДУУЛАХ дотуурдахын үйлдүүлэх хэв.

ДОТУУРЛАХ дотуур болгон үзэх, аминчлах.

ДОТУУРХАН арай дотуур.

ДОТУУРХАХ дотуурлан үзэх; *танил хүмүүсээ дотуурхаж байжээ.*

ДОХИВЧЛОХ байн байн дохих.

ДОХИГО: дохиго дохиго хийх дохигор юмны үргэлжлэн хөдлөх.

ДОХИГНОХ 1. дохигор юмны дохиго дохиго хийх; 2. ш и л ж с э н ая байдалд тохируулан бялдуучлан явах; **нахиганах дохигонох** х о р ш .,

ДОХИГОР нарийн урт өндөр бөгөөд бөхгөр; *дохигор өндөр хүн; дохигор урт мод.*

ДОХИЙЛГОХ дохийхын үйлдүүлэх хэв.

ДОХИЙХ дохигор болох, тахийх.

ДОХИЛЗОХ дохигор юмны дохис дохис хийж хөдлөх.

ДОХИО бусдад мэдрүүлэхээр өгөх тэмдэг; **дохио тэмдэг** х о р ш.; *гар дохио; гэрэл дохио;* **дохио авах** (бусдаас өгсөн дохио тэмдгийг мэдэх); **дохио өгөх** (мэдрүүлэх тэмдэг үзүүлэх ба үзэгдүүлэх): **дохионы бичиг** х у у ч и р с а н (орчуулгын толь бичиг).

ДОХИОЛОХ дохио өгөх, нүд ирмэх.

ДОХИОЧ дохио өгөгч хүн.

ДОХИС: дохис дохис хийх дохигор юмны байн байн хөдлөх.

ДОХИСХИЙХ түр зуур дохих.

ДОХИУЛАХ дохихын үйлдүүлэх хэв.

ДОХИУР I хөгжмийн зэвсгийг цохиж дуугаргахад зориулсан хэрэглэл; *хэнгэргийн дохиур; бөмбөрийн дохиур.*

ДОХИУР II цэцгийн тоос агуулах эрхтэн; *цэцгийн дохиур.*

ДОХИХ 1. дохио өгөх; *гараар дохих; хуруугаар дохих; нүдээр дохих;* 2. хөгжимчдөөс хөгжмийн зохиол тоглох, дуучдаас найрал дуу дуулахад удирдах; *энэ хүн сайхан дохиж байна;* 3. толгойг бөхөсхийх; *зөв гэж толгой дохив;* 4. үүрэглэх; *нойр муутай хоносон учир хичээл дээрээ дохиж байжээ.*

ДОШ 1. овойж мөстөн хөлдсөн газар; *дош овойх; овгор дош;* 2. нүхний амсрын овгор газар; *тарваганы дош.*

ДОШГИДОХ догшдох.

ДОШГИН догшин.

ДОШГИРОХ догшрох.

ДОШГИРУУЛАХ дошгирохын үйлдүүлэх хэв, дошгин болгох.

ДОГШИРХОХ догшин зан байдал гаргах.

ДОШЖИХ доштой болох.

ДОШЛОХ дош тогтох, дошдох.

ДОШРОХ дош болох; *ус доширсон байв.*

ДОШДОХ дош бий болох.

ДӨВ: дөв дөрвөлжин шоо дөрвөлжин; *дөв дөрвөлжин хайрцаг.*

ДӨЖ I дөжин; *дөж болсон амьтан.*

ДӨЖ II бог малыг хөөх туухад гаргах аялга; *цаад хонь ямаагаа дөж гээч.*

ДӨЖИН үг сургамжийг авдаггүй, үл мэдэхчлэн явдаг; **дүлий дөжин** х о р ш.; *дөжин хүнд үг хэлснээс дүлий хүнд хэлбэл дээр;* **дөжин болох** (дүлий дөжин мэт явж азад болох).

ДӨЖИР 1. түргэн алжаах, цуцахгүй; *дөжир морь;* 2. хялбар эвдрэхгүй, бэх бат; *дөжир эд;* 3. авад хөдлөхгүй, хойрго; *дөжир хойрго хүн.*

ДӨЖИРЛӨХ 1. тэвчээр гаргах, тэсвэрлэх; 2. дөжир зан гаргах; 3. дөжир хүний үйл явдлаас булталн явах.

ДӨЖРӨХ I чимээ, дуу, яриа үргэлж сонсоор тоохгүй, ажиггүй байх; юм сонсохгүй болох; *чих дөжрөх*

ДӨЖРӨХ II дөжир дөжин болох.

ДӨЖРҮҮЛЭХ дөжрөхийн үйлдүүлэх хэв, дөжир болгох.

ДӨЛ I улайсч шатан гэрэлтэж байгаа хий, галын өрвөлзөн бадрах нөл; *галын дөл; лаа-ны дөлөнд үсээ хуйхлав.*

ДӨЛ II 1. уулын хэлбийгүүгийн түвшхэн буусан газар; *уулын дөл газар;* 2. урсгал усны ойр байгаа дөлгөн түвшин газар; *усны дөл газар.*

ДӨЛ III энгийн зүгээр, ерийн байдлаар, амиараа; *дөлөөрөө яваа; дөл унаагаар явна;*

ДӨЛГӨН амарлангуй, тайван; *дөлгөн хүн; дөлгөн түвшин.*

ДӨЛГӨӨН 1. алгуур, удаан, тайван, назгай; *дөлгөөн салхи; Номхон Дөлгөөн далай;* 2. ш и л ж с э н өндөр бөгөөд эгц биш, аюухан буусан налуу газар; *дөлгөөн газар;* 3. ш и л ж с э н халуун хүйтний намжуу, тааруу; *энэ өдөр дөлгөөн сайхан өдөр байна.* 4. ш и л ж с э н яруухан аятай; *дөлгөөн дуу сонсдов;* 5. ш и л ж с э н номхон, түвшин, эелдэг; *дөлгөөн зан; дөлгөөн хүн.* •

ДӨЛГӨӨРӨХ дөлгөөн болох, зөөлөн намдуу болох; *салхи дөлгөөрөх.*

ДӨЛӨЛЗӨХ дөлөнцөг, дөлцөг.

ДӨЛӨНЦӨГ монгол дээлийн гадаад хормойн суга ташаа дагаж байх зах тал; *эмэгтэй хүний дээлийн дөлөнцгийг эмжих.*

ДӨЛӨӨРӨХ дөлгөөрөх; *салхи дөлөөрөх.*

ДӨЛӨХ юманд халж халдаж ядан зайцах, цэрвэх; *ойртож чадахгүй дөлж байв; холуур дөлж явах.*

ДӨЛРӨХ модон савны уулзар ангайх, салах.

ДӨЛЦӨГ дөлөнцөг.

ДӨМГӨР зан байдал түвшин, эелдэг, аятай; *дөмгөр сайхан эр; дөмгөр морь.*

ДӨМИЙХ 1. дөмгөр болох; 2. дөвийх.

ДӨМНӨХ 1. юмыг ор нэрийн төдий хийх; *бичих гэж дөмнөсөн байна;* 2. дэмнэх; *чи үүнийг дөмнөж байгаач.*

ДӨМӨГ овоо, зэгсэн, нилээд сайн; *дөмөг эд эдлэхэд нүнжигтэй; дөмөг мориор явахад өдөртөө хүрэх газар.*

ДӨМӨГХӨН нилээд дөмөг.

ДӨМӨХ 1. хэрэглэгдэх зүйл арай ядан хүрэх, дөнгөж бололцюх; *амьдралаар дөнгөж дөмж явна;* 2. үйл үйлдвэрг өчүүхэн төдий дэмнэх, дөмнөх; 3. үйл явдлыг хийхэд ор нэр болгон ам хааж домнох.

ДӨНГӨ 1. х у у ч и р с а н ялтны хүзүүнд өмсгөх дундаа нүхтэй зүймэл дөрвөлжин банз; *хүзүүнд нь дөнгө өмсгөж, хөлд нь гав торгож шийтгэ!;* 2. гэрийн хаяагаар оруулахгүйн тул нохойн хүзүүнд уях уртавтар нарийн мод; *дөнгөтэй нохой;* 3. ш и л ж с э н тээр дараа, саад тотгор, төвөгшөөлтэй явдал; *надад тун дөнгөтэй ажил тохиолдов.*

ДӨНГӨЖ 1. чуу чамай, арай чарай; **дөнгөж дангаж** х о р ш.; *дөнгөж үүр цаймагц;* 2. ердөө; зөвхөн; *дөнгөж гуравхан; дөнгөж нэг аяга цай уугаад явлаа;* 3. тун саяхан; *дөнгөж сая орж ирэв; дөнгөж сая гүйцэв.*

ДӨНГӨЛӨХ 1. дөнгө өмсгөх, дөнгөтэй болгох; 2. ш и л ж с э н тээртэй ажил үүрүүлэх, даалгах.

ДӨНГӨЛҮҮЛЭХ 1. дөнгөлөхийн үйлдүүлэх хэв; 2. дөнгөлөгдөх.

ДӨНГӨН: дөнгөн данган чуу чамай, арай чарай, зөвхөн; *замд морь эцээд дөнгөн данган ирлээ; галт тэрэг хөдлөхөөс өмнө дөнгөн данган хүрэв.*

ДӨНГӨХ арай чарай гүйцэтгэх, муухан хийх, бүтээх, чадах; *муухан дөнгөлөв; ашгүй дөнгөжээ; хийж дөнгөх; хэлж дөнгөх; идэж л дөнгөх байх.*

ДӨНГҮҮЛЭХ 1. дөнгөхийн үйлдүүлэх хэв: 2. дөнгөгдөх, давагдах, дийлэгдэх ,чадагдах.

ДӨНГҮҮР арай дээр, арай олигтой; *дөнгүүр юм; арай дөнгүүр.*

ДӨНГҮҮРХЭН нилээд дөнгүүр.

ДӨНДГӨ: дөндгө дөндгө хийх дөндгөр юмны үргэлжлэн хөдлөх.

ДӨНДГӨР онцгор; *дөндгөр мод; дөндгөр хад.*

ДӨНДИЙЛ дөндийлөг.

ДӨНДИЙЛӨГ өрхийг дороос нь тулж хөндийлөх мод; *өрхний дөндийлөг.*

ДӨНДИЙЛӨХ дөндийлгөөр тулж хөндийлөх; *өрх дөндийлөх.*

ДӨНДИЙЛҮҮЛЭХ дөндийлөхийн үйлдүүлэх хэв.

ДӨНДИЙХ дөндгөр болюх .

ДӨНДӨГНӨХ дөндгөр юмны дөндөг дөндөг хийх.

ДӨНДӨГНҮҮЛЭХ дөндөгнөхийн үйлдүүлэх хэв.

ДӨНДӨЛЗӨХ дөндгөр юмны дөндөс дөндөс хөдлөх.

ДӨНДӨЛЗҮҮЛЭХ дөндөлзөхийн үйлдүүлэх хэв.

ДӨНДӨС: дөндөс дөндөс хийх дөндгөр юмны байн байн хөдлөх.

ДӨНЖ (ИН) дөрвөн настай эм үхэр, тэмээ; *дөнжин үнээ; дөнжин тэмээ; дөнжин дөнжин тэмээнээс, дөрвөн атга шороноос* (ардын аман зохиол).

ДӨНӨ (Н) дөрвөн настай эр үхэр, тэмээ; *дөнөн үхэр; дөнөн тэмээ.*

ДӨР I 1. хамрын баганыг цоолон хөндлөн шургуулсан хамагч мод, мөн хамрын нүхээр оосорлосон оосор; *үхрийн дөр;* **дөр хамагч** х о р ш.: **дөргүй бух шиг** ш о о д с о н (учир мэдэхгүй зүтгэдэг хүн); **дөрөө мэдэхгүй** (хатуу хамартай); 2. анжисны бөхийн үзүүрт хадсан гогодон торгох төмөр; 3. суулга сэвгийн дээдэд хөндлөн хийсэн бариул; 4. усны гарам: 5. худраганы үзүүрийн дотор талд хадсан гархитай төмөр; 6. эрэг шургийг харьж эргэхээс сэргийлэн шургуулж хийсэн тээг.

ДӨР II юмны эв, ая; *би яаж хийхийнхээ дөрийг олохгүй байна;* **ажлын дөр мэдэхгүй** (ажил хийж огт сураагүй).

ДӨР III төрх байдал; **дөр төрх** х о р ш.; *дөр нь зүгээр сайн хүн шиг байна билээ.*

ДӨРВӨД монголын нэг ястан.

ДӨРВӨЛ дөрвөөр дуулах буюу хөгжимдөхөд тохируулсан хөгжмийн зохиол; *дөрвөл хөгжим; дөрвөл дуу.*

ДӨРВӨЛЖ I 1. дөрвөлжин юмыг дөрөв хуваасны нэг болох эн дөрвөлжин хэсэг; *дөрвөлж даавуу;* 2. дөрвөлжин хэлбэртэй сав; *аргалын дөрвөлж;* 3. наадах төлгөдөхөд хэрэглэх шоо; *дөрвөлж орхих.*

ДӨРВӨЛЖ II у р г а м а л 1. олмос гэдэг өвс; 2. дөрвөлжлөн боосон боодолтой өвс; *нэг дөрвөлж өвс авъя, ямар үнэтэй вэ?.*

ДӨРВӨЛЖИН 1. дөрвөн талтай, тал бүр нь адил тэгш өнцөгт; *босоо дөрвөлжин: шоо дөрвөлжин; босоо дөрвөлжин сантиметр; 1 га буюу 10000 хавтгай дөрвөлжин метр; өдөр гурвалжин, шөнө дөрвөлжин* о н ь с г о; *ам дөрвөлжин; хавтгай дөрвөлжин* (тал бүр нь адилхан тэгш өнцөгт); **гонзгой дөрвөлжин** (тэгш өнцөгт дөрвөлжин); 2. хөзрийн дүрс; *дөрвөлжингийн боол; дөрвөлжингийн ноён;* ☆ **дөрвөлжин бичиг** (1269 онд Пагва ламын зохиосон нэг зүйл монгол бичиг).

ДӨРВӨЛЖЛӨХ 1. дөрвөлжин болгох; *дөрвөлжлөн нугалах; 2.* ш и л ж с э н бөхийн лавлан барилцах, шуудаг шуудаг дээрээсээ барилцах мэх; *дөрвөлжлөн авч барилдав.*

ДӨРВӨЛЖЛҮҮЛЭХ дөрвөлжлөхийн үйлдүүлэх хэв.

ДӨРВӨӨД тус тус дөрөв, дөрөв шахам.

ДӨРВҮҮЛ дөрвөн тоотой юмны нэгэн хамт; *дөрвүүл ирэв; дүүдий дүүдий дөрвүүл.*

ДӨРГӨР даргар, дөрдгөр; *тэр авдрын банз хатаж дөргөр болсон байна.*

ДӨРДГӨР дорсгор, дөрсгөр.

ДӨРДИЙЛГӨХ дөрдийхийн үйлдүүлэх хэв, дөрдгөр болгох.

ДӨРДИЙХ дөрдгөр болох ,дөрсийх.

ДӨРДӨГНӨХ дөрдгөр юмны үргэлжлэн хөдлөх.

ДӨРДӨЛЗӨХ дөрдгөр юмны байн байн хөдлөх.

ДӨРИЙХ дөргөр, дөрдгөр болох; *хатсан арьсны год мэт дөрийжээ; дэвсгэрийн сэжүүр дөрийх.*

ДӨРЛӨХ 1. дөр зүүх, дөр хийх; 2. ш и л ж с э н юмыг эрх мэдэлдээ оруулах; *тэр түүнийг нэгмөсөн дөрлөж авсан хүн.*

ДӨРЛҮҮЛЭХ 1. дөрлөхийн үйлдүүлэх хэв; 2. дөрлөгдөх.

ДӨРӨВ (ДӨРВӨН) 1. дөрвийн тооны нэр, гурав дээр нэгийг нэмсэн нь; *хоёр хоёрын дөрөв; дөрвөн ширхэг; дөрвөн давхар;* **дөрвөн бэрх орхих** (дөрвөн шагаа орхиж дөрвөн өөр буулгах); **дөрвөн гишүүн** (хоёр гар, хоёр хөл): **дөрвөн мөч, дөрвөн хөл** (а. хүний дөрвөн гишүүн; б. амьтны хоёр хаа, хоёр гуя); **дөрвөн хөллөх** (хоёр гараараа газар тулж бөхийх); **дөрвөн улирал, дөрвөн цаг** (хавар, зун, намар, өвөл); **дөрвөн зүг** (умар, өмнө, дорно, өрнө): **дөрвөн зовхис** (дөрвөн зүгийн завсар); **дөрвөн өндөр хавирга** (хааны дөрвөн урт хавьс; *дал дөрвөн өндөр):* **дөрвөн хүүхэд** (Өвөрмонголын нэгэн аймгийн нэр); **дөрвөн таа** (дөрвөн удаа); 2. дөрэвний өдөр; *өнөөдөр 8-р сарын дөрвөн.*

ДӨРӨВДҮГЭЭР дараалсан тооны дөрвөд тохиолдсон нь; *дөрөвдүгээр сар; дөрөвдүгээр боть.*

ДӨРӨВЛӨӨС нэгэн хэсэг юм буюу дугаригийг дөрөв хуваасны нэг.

ДӨРӨВЧ ногт, цулбуур.

ДӨРӨГНӨХ дөргөр дөрдгөр юмны дөрөг дөрөг хөдлөх.

ДӨРӨЛЖ уул ухаа хамар газрын гудас хөтөл; *Сонгинын дөрөлж дээр гарч ирэхэд нийслэл хот маань илхэн харагдав.*

ДӨРӨЛЗӨХ дөрдгөр дөргөр юмны дөрс дөрс хийх.

ДӨРӨЛЗҮҮЛЭХ дөрөлзөхийн үйлдүүлэх хэв.

ДӨРӨӨ 1. эмээл, тохшинд зүүж гишгэн мордох, төмөр зэргээр хийсэн хэрэглэл; *эмээлийн дөрөө; тохошны дөрөө; төмөр дөрөө; дөрөө хангинуулах; дөрөө хавирах;* **дөрөөний толь** (дөрөөний таваг); **дөрөөний цагираг** (дөрөөний хавирга); **дөрөөний сэнж** (дөрөөний сур оруулах сүв); **дөрөөний сур** (дөрөө дүүжлэх сур); **дөрөө хөдөлгөх** (давирах); **дөрөө тэмцэх** (морь малын мордуулахгүй зайлсхийх): **дөрөөний хавирга** (дөрөөний хажуу); **дөрөөний зага** (дөрөөний дээд угалз); **дөрөөний таваг** (дөрөөний дорхи хавтгай); **дээсэн дөрөөтэй** (дөнгөн данган; *шалгалтанд арай ойчсонгүй, дээсэн дөрөөтэй л гарлаа):* **гары нь ганзганд, хөлий нь дөрөөнд хүргэх** (аж төрж амьдарч чадахуйц болгох): 2. хөлөөр гишгэх гишгүүр; *машины дөрөө гишгэх;* 3. юм өөд асах авирахад гишгэхээр зориулан хийсэн дүүжин, оосор, гишгүүр; *шон модонд авирах дөрөө.*

ДӨРӨӨВЧ 1 нэгэн зүйл нарийхан гөлөм; *дөрөөвчин гөлөм;* 2. эмээлд зүүж барьж явж

юм хумыг торгон тогтоож дэм өгөх оосор; *туг барих хун, эмээлдээ дөрөөвчтэй бол биенд амар байдаг;* 3. дөрөө дөрөөлдөг юм; *чи миний дөрөөвчийг үзэв үү?;* 4. нохой хөтлөх оосор.

ДӨРӨӨВЧЛӨХ 1. барьж явах юмыг эмээлийн дөрөөвчөөр торгон тогтоож авч явах; *туг далбаагаа дөрөөвчлөн бариад явлаа;* 2. шаштин хэнгэрэг цан хоёрыг нэг хүн дуугаргах; *хэнгэрэг цан дөрөөвчлөн дэлдэж байв.*

ДӨРӨӨЛӨХ 1. дөрөөн дээр гишгэх; *дөрөөгөө дөрөөлөх хэрэгтэй; мод өвд дөрөөлж гарах;* 2. морь малын биений дөрөө орших орчны хэсэг газар; *дөрөөлөхий нь хатгах.*

ДӨРӨӨЛҮҮЛЭХ дөрөөлөхийн үйлдүүлэх хэв.

ДӨРСГӨНӨХ дөрсгөр юмны үргэлжлэн хөдлөх.

ДӨРСГӨР дөргөр, дорсгор, дордгор; *дөрсгөр хад; дөрсгөр арьс.*

ДӨРСИЙЛГӨХ дөрсийхийн үйлдүүлэх хэв, дөрсгөр болгох.

ДӨРСИЙХ дөрсгөр, дөрдгөр болох ,дөрдийх.

ДӨРСӨЛЗӨХ дөрсгөр юмны байн байн хөдлөх.

ДӨТ арай ойр, илүү ойр, дотно; *дөт зам; дөтөөр битгий яваарай, тойрч яваарай гэж гэнэ* (үлгэрээс); *дөтөөр явах гэсэн чинь дөрөв хонов; тэр чинь надад нилээд дөт хүн шүү.*

ДӨТЛӨХ 1. дөт замаар явах; 2. ойртох, ойр болох; 3. хүрэх, дуусах, шахамдах; 4. илүү дотно үзэх.

ДӨТЛҮҮЛЭХ дөтлөхийн үйлдүүлэх хэв.

ДӨТЧИЛӨХ дөт замаар явах, ойр замаар явах; *би дөтчилөөд хойт замаар явав.*

ДӨТЧИЛҮҮЛЭХ дөтчилөхийн үйлдүүлэх хэв.

ДӨТЧИЛҮҮР дотно, тал харамтгай; *дөтчилүүр хүн.*

ДӨХӨМ хялбар, амар, тус, ашиг; **тус дөхөм, хялбар дөхөм** хорш.; *явдлын дөхмийг харж, хөгөөр явсан нь их дөхөмтэй биш үү?.*

ДӨХӨМГҮЙ амаргүй, хялбаргүй, тус ашиггүй; *дөхөмгүй зам; дөхөмгүй хэрэг.*

ДӨХӨМЖ дөхөм; *дөхөмж сайтай; дөхөмж муутай.*

ДӨХӨМГҮЙ дөхөмж муутай, хялбар дөхөмгүй.

ДӨХӨМЛӨХ үйл явдлыг дөхөм болгох.

ДӨХӨМТЭЙ дөхөм бүхий; ашигтай; *энэ ажлыг яаж хийвэл дөхөмтэй байх вэ?.*

ДӨХӨХ I .ойртох, ойртож ирэх; **ахих дөхөх** хорш.; *биднийг хотод дөхөж очтол...;* 2. өдөр сарын хоног хугацаа ойртох; *шинэ жил гарах дөхөж байна; хугацаа дөхөх;* 3. ажил явдлын төгсгөл ойртох; *унших дуусах дөхөж байна.*

ДӨХҮҮ 1. ойрхон, ойршиг, дөхөм; *дөхүү газар; үүгээр явбал дөхүү;* 2. ахиу; **ахиу дөхүү** хорш.; 3. ойролцоо, ижилдүү, төстэй.

ДӨХҮҮЛЭХ дөхөхийн үйлдүүлэх хэв, ойртуулах.

ДӨХҮҮХЭН нилээд дөхүү.

ДӨЧ (ИН) дөрвөн арвын нийлбэр тоо; *дөчин настай; дөчин километр.*

ДӨЧДҮГЭЭР дэс тооны дөчид тохиолдсон тоо; *дөчдүгээр хуудаснаа бий.*

ДӨЧИНТАА дөчин удаа.

ДӨЧӨӨД дөч орчим, тусбүр дөч; *говьд дөчөөд тэмээ явж байна билээ; хүн дутам дөчөөд төгрөг өг!.*

ДӨЧҮҮЛ дөчин тоотой юм хамт; *бид дөчүүл байна.*

ДӨШ 1. төмрийн зүйлийг тавьж давтан цохих төмөр хэрэгсэл; *дархны дөш; дөшний толь; дөшний суурь;* **алх дөш** хорш.; 2. бие бүтцийн зүй, дунд чихний нэгэн жижиг яс.

ДРАМА жүжиг; *драмын театр.*

ДРАП цэмбэ; *Улаанбаатар драп.*

ДУВ хүч нэмэгдүүлэх үг; **дув дуугай** (огт дуугарахгүй, чив чимээгүй); **дув дугай** (маш дугай).

ДУГ I: **дуг нойр** ид унтаж байгаа цаг; *дуг нойр дунд нь дуудав.*

ДУГ II шатар наадахад тэмээгээр дулахад өгүүлэх аялга.

ДУГААР 1. эр эгшигт тооны нэрд залгах дэс тооны дагавар; *хоёрдугаар; гуравдугаар; аравдугаар;* 2. нэг төрлийн олон юмны дэс дараалсан тоо; *хаалганы дугаар; сэтгүүлийн дугаар; машины дугаар;* 3. юмны зэрэг дэс; *дугааргүй гурил; хоёрдугаар нарийн бичгийн*

дарга; 4. хувцас юмны хэмжээг заасан тоо, номер; 5. тоо дараг нууцлан өгүүлэхэд; *...дугаар анги; ...дугаар морьт хороо.*

ДУГААРЛАЛ дугаарлах үйлийн нэр, дараалал.

ДУГААРЛАХ 1. дэс дараалах, дугаартай болгох, дугаар тавих; *бичиг дугаарлах; эд хогшлыг тоолж дугаарлах;* 2. дэс дараатай болох, эрэмбэ дараатай болох; *дугаарлан зогсох.*

ДУГААРЛУУЛАХ 1. дугаарлахын үйлдүүлэх хэв; 2. дугаарлагдах.

ДУГАЙ дуугүй, чимээгүй, дугардаггүй; *дугай байх; дугай!; дугай бай!; дугай хүн.*

ДУГАН шашны сүм; **сүм дуган** хорш.

ДУГАНЦАГ эмэгтэйчүүдийн өмсөх богино түрийтэй гутал.

ДУГАНЧ шашны дуганы харгалзагч.

ДУГАРАА I найр хийхэд оролцсон хүн бүхэнд гардуулан өгөх айраг архи; *анхны дугараа, дугараа барих.*

ДУГАРАА II **ээлж дугараа** дэс дараалаараа; *ээлж дугараагаараа хийх.*

ДУГАРАХ I 1. дуу гарах; *бүдүүн дугарах, нарийн дугарах; үйлдвэрийн яндан дугарав; шувуу дугарах; тэнгэр дугарах;* 2. шилжэн үг хэлэх; *юм болгон дээр дугарахаас бэрхшээжээ.*

ДУГАРАХ II найр хийхэд оролцогчдод айраг архи өгөх.

ДУГАРГАХ дугарахын үйлдүүлэх хэв; дугарахад хүргүүлэх; *хүлээн авагч дугаргах; радио дугаргах.*

ДУГАРИГ дугуй хэлбэртэй; *дугариг хүрээтэй; дугариг хэлбэртэй; зуувал дугариг.*

ДУГАРИГДУУ дугуй байдалтай.

ДУГАРИГЛАХ дугариг болгох, дугуй болгох.

ДУГАРИГЛУУЛАХ дугариглахын үйлдүүлэх хэв.

ДУГАРИГХАН арай дугариг.

ДУГАРИНХАЙ гахайн нарийн гэдэс.

ДУГАРМАГЛАХ I дупаран ядах.

ДУГАРМАГЛАХ II дугараа барих.

ДУГАРУУЛ тариа тарихад хэрэглэх нэгэн зүйл багаж, үр сацсаны дараа дээгүүр нь даран чирэх хоёр чулуун хүрд.

ДУГАРУУЛАХ дугарахын үйлдүүлэх хэв, дугарахад хүргүүлэх.

ДУГГҮЙ 1. сэггүй; *бороо дуггүй оров;* 2. огт унтсангүй; *дуг хийлгүй хонов .*

ДУГЖРАХ унтах, дугхийх; *хүүхэд дугжирч байна.*

ДУГНИУН хүний дотор тодорхойгүй болох, мансуурах.

ДУГТАР амьтан мөрөн голд оршдог, бие нь хавтгай, өнгө цагаан, эртгэр хушуутай, хайрс нарийн нэгэн зүйл загас.

ДУГТАРХИЙЛЭХ байн байн дугтрах.

ДУГТРАХ 1. гэнэт угзран доош нь татах; *хоёр гар дээрээс нь хүчтэй дугтран, газар сөгтөв; дугтардаг морь;* 2. бөхийн мэх, нөгөө этгээдийг доош нь даран угзрах; *дугтран унагав;* 3. сугсрах, огзом огзом сэгсрэн доош нь оруулах; *дүүрэн будаатай хүүдийг дугтарсаар байж нилээд доош нь оруулжээ; бахардсан хүнийг сэргээхээр дугтрав.*

ДУГТРУУЛАХ 1. дугтрахын үйлдүүлэх хэв; 2. дугтрагдах.

ДУГТУЙ 1. юманд углах гэр, хуй; *дэвүүрийн дугтуй; тонгоргийн дугтуй;* 2. юмны үзүүрт углах углуур; *бийрний дугтуй; харандааны дугтуй; үзүүртээ булигаар дугтуйтай ташуур; эсгэсэн хуруундаа резин дугтуй хийв;* 3. бичиг захидал агуулж илгээх цаасан уут; *захидлын дугтуй; дугтуйтай бичиг;* 4. дэгтий.

ДУГТУЙЛАХ юмыг дугтуйд агуулах, дугтуйтай болгох; *захиагаа дугтуйлав.*

ДУГТУЙЛУУЛАХ дугтуйлахын үйлдүүлэх хэв.

ДУГТЧИХ байн-байн дугтрах, угзчих.

ДУГТЧУУЛАХ дугтчихын үйлдүүлэх хэв.

ДУГУЙ 1. дугариг, дүгриг; *сар шиг дугуй; сам шиг садархай* оньсго; *дугуй малгай духдуулан тавьжээ; дугуй царайтай;* 2. юмны хүрд, хүрдэт юм; *унадаг дугуй; моторт дугуй; тэргний дугуй; машины дугуй; дугуйн уралдаан; дугуйгаар аялах;* 3. дугуй хэлбэртэй хийсэн зарим идээний зүйл; *гавжийн дугуй; дугуй цагаан; дугуй аарцуул.*

ДУГУЙЛАН 1. ардын тэмцлийн бүлгэм (толгойлсон хүнгүй бүгд санал нэгтэй гэдгийг илэрхийлэхийн тул эсэргүүцэн тэмцэх заргын бичигт нэрсээ тойруулан зурж байснаас үүссэн үг; *цэцэг нуурын дугуйлан;* 2. хамтран хичээл хийхээр нэгдсэн хэсэг хүмүүс; *монголын түүх судлах дугуйлан; марксизм-ленинизмийг судлах дугуйлан; утга зохиолын дугуйлан; дугуйлангийн багш.*

ДУГУЙЛАХ 1. дугуй болгох; *дугуйлж зурах;* 2. хаах, гүйцсэнд тооцох, үгүй болгох; **данс дугуйлах** (данс хаах).

ДУГУЙЛДАХ 1. дугуй юмны өнхрөх; *тэрэгний дугуй дугуйлдаад би хойноос нь хөөгөөд гүйцсэнгүй;* 2. толгойгоороо тонгорон унах; *дугуйлдаж ойчих;* 3. бөхийн мэх, дунгуйлдах.

ДУГУЙЛДУУЛАХ дугуйлдахын үйлдүүлэх хэв.

ДУГУЙЛУУЛАХ дугуйлахын үйлдүүлэх хэв.

ДУГУЙРАХ дугуй болох; *дугуйран давхих; дугуйрсан эвэртэй хонь.*

ДУГУЙРУУЛАХ дугуйрахын үйлдүүлэх хэв.

ДУГУЙТ дугуйтай; **дугуйт өргүүл** (хүнд жинтэй юмыг өргөхөд зориулсан дугуйтай хэрэгсэл).

ДУГУЙТАЙ дугуй бүхий.

ДУГУЙЦАХ дугуйран зогсож наадах нэгэн зүйл тоглоом; *хүүхдүүд дугуйцаж тоглов.*

ДУГУУНИХ толгой дүйрэх, эргэх, нүд эрээлжлэх; *толгой дугууних.*

ДУГХИЙХ түргэн зуур унтах; *үүрээр жаахан дугхийчихэв.*

ДУДРАЙ 1. нялх хурга, ишиг; *дудрай хурга;* 2. ядуу дорой, тэнхэл муутай; *дудрай амьтан.*

ДУДРАН илжигний унага.

ДУЖИГНАХ түргэн хэлэх; *энэ хүн илгэл хийх нь дужигнаад л өнгөрөх юм.*

ДУЖИГНУУЛАХ дужигнахын үйлдүүлэх хэв.

ДУЛ: дул өдөр тэнгэр цэлмэг, салхигүй, тогтнуун сайхан өдөр; *намрын тэр нэгэн дул өдөр бид мордож бидээ.*

ДУЛАА дулах (шатарт): **тэмээний дулаа** (тэмээний шалаа).

ДУЛААВТАР дулаан шиг, бага зэрэг дулаан.

ДУЛААДАХ нэндүү дулаан болох.

ДУЛААЛАЛТ дулаалах үйлийн нэр; *дулаалалтын систем.*

ДУЛААЛАХ дулаан болгох; *гэр дулаалах; хашаа хороогоо дулаалах.*

ДУЛААЛУУЛАХ дулаалахын үйлдүүлэх хэв.

ДУЛААН 1. бодисын хөдөлгөөний тусгай хэлбэр болох бодисын өчүүхэн хэсгүүдийн хөдөлгөөнөөр бий болох илч; *дулааны илч;* 2. үл дааруулах, илч сайтай; *дулаан дээл; дулаан улирал; дулаан байшин; дулаан орох;* 3. ш и л ж с э н нөмөр сайтай; *өвөр ээвэр газар дулаан; дулаан өвөлжөө;* 4 .ш и л ж с э н аятайхан, дотно; *нүдэнд дулаан хүн; нүдэнд дулаан харагдах хувцас.*

ДУЛААРАХ цагийн улирал дулаан болох; *хавар эрт дулаарав.*

ДУЛААРУУЛАХ дулаарахын үйлдүүлэх хэв.

ДУЛААХАН нилээд дулаан.

ДУЛААЦАХ биеийн жихүүцлийг арилгах; *галд дулаацах; бие дулаацаж байна.*

ДУЛААЦУУЛАХ дулаацахын үйлдүүлэх хэв; *хөлөө дулаацуулах.*

ДУЛААШРАХ улмаар дулаан болох.

ДУЛАН а м ь т а н далайн загас, жижигхэн амтай, хайрсгүй, бие нь гарын алга мэт хавтгай, арьс маш ширүүн, үүний арьсаар нумны сум шивэлдэнэ.

ДУЛАХ I шатар наадахад тэмээгээр шалах; *цагаан тэмээгээр дулав.*

ДУЛАХ II атгасан гараар бусдын толгойн тус газар дэлдэх; *баруун шанаа руу нь нэг дулаад авав.*

ДУЛДУЙ 1. хангинуулах таяг, буддын шашны ёсны гэлэн хүн биеэ хамгаалах зорилготой авч явдаг хэрэгсэл; *урьд дулдуйтай бадарч үзэгддэг байлаа;* 2. ш и л ж с э н биенээс салдаггүй үргэлж тэврээстэй бариастай байх зүйл; *хүүхдээ дулдуй шиг тэвэрч байдаг хүн.*

ДУЛДУЙДАХ түшиг тулгуур болгох, найдлага түшиг болгох, найдварлах; *хурдан буундаа дулдуйдах; тусламжинд дулдуйдах; баримт материалд дулдуйдан зохиов*

ДУЛДУЙЧ дулдуй барин түүний магтаалыг уншиж юм гүйгч хүн.

ДУЛИА нягт агаараас салж одох үүл; *дулиа гарч эхлэв.*

ДУЛИАРАХ дулиа үүл гэнэт сарнин арилж тэнгэр цэлмэх.

ДУЛИМ: дутуу дулим дутуу хагас.

ДУЛИМАГ дульхан, дутмаг; **дутуу дулимаг** х о р ш.; *шийдвэрлэх асуудлыг дутуу дулимаг боловсруулж болохгүй!*

ДУЛУУЛАХ дулахын үйлдүүлэх хэв.

ДУЛЬ I. дунд, дүүрэн биш, дутуу; *дутуу дуль; дуль бүү хийгээрэй; чадлаар дуль:* 2. ш и л ж с э н барагтайхан, муухан; **дуль хүчтэй** (асар тарган биш); *сурлагаар дуль.*

ДУЛЬХАН нилээд дуль, барагтайхан; *сурсан эрдмээр дульхан хүн байна.*

ДУМБАГАР бумбагар; *манайд хөөрхөн дум багар жаал орж ирлээ.*

ДУМБАЙЛГАХ думбайхын үйлдүүлэх хэв.

ДУМБАЙХ думбагар болох.

ДУН 1. зарим нуруугүй амьтны бие хамгаалах хатуу бүрхүүл гэр: **дун бүрээ** (мөнхүү бүрхүүл гэрийг засч хийсэн хөгжмийн үлээх зэвсэг); *үлээдэг дун;* **дун цагаан** (маш цагаан); 2. дун дотор орших нялцгай биетэн; *дун хорхой.*

ДУНАГАР данагар, дунхгар; *дунагар морь дунагар айл.*

ДУНАЙЛГАХ дунайхын үйлдүүлэх хэв, дунайхад хүргүүлэх.

ДУНАЙХ дунагар болох.

ДУНАЛЗАХ дунагар юмны хөдлөх, дунхалзах.

ДУНАЛЗУУЛАХ дуналзахын үйлдүүлэх хэв.

ДУНГУЙ 1. дундгуй; 2. бөхийн мэх; **сэрээн** дунгуй хийх (нөгөө бөхийн биеийг өөрийн бие дээрээ татан авч эргүүлдэн хөмөрч унагаах).

ДУНГУЙЛАХ дунгуйлдах.

ДУНГУЙЛДАХ 1. дугуйгаараа өнхрөх, ойчих; 2. дунгуй хийх;

ДУНД 1. юмны голд, төвт, хооронд; *нуурын дунд; хотын дунд; хоёр байшингийн дунд;* 2. дотор; *олны дунд; үгний дунд; явцын дунд;* 3. ш и л ж с э н төв, гол; *тэг дунд;* **төв дунд;** *өр дунд; дундыг баримтлах;* **дунд нь байж** *харах; өдөр дунд; сарын дунд; шөнө дунд;* 4. дээд биш, доод биш, хоорондын; *хоёрын хооронд, гурвын дунд; өвлийн дунд сар; дунд сургууль; дунд тушаалын дарга; дунд үн авах;* **дунд хуруу** (гарын гуравдугаар хуруу); **дунд чөмөг** (сүүж шаант хоёрын хоорондох чөмөг яс); 5. ш и л ж с э н үед, цагт; *ажлын дунд; нойрны дунд; зүүдэн дунд;* 6. ш и л ж с э н барагтайхан, хангамжгүй; төдий сайн биш, дээд зэрэг биш; *их тарган биш, дунд зэргийн хүчтэй; чанараар дунд эд; дунд зэргийн нуруутай; сэтгэлд дунд байна;* 7. дүүрэн биш, хагасын хирд, дундуур; *усыг хувинд дунд хийжээ; миний аягатай цай дунд байна; дундыгаа дүүргэж дутуугаа гүйцээ.*

ДУНДАД дунд бүхий, дунд хир, дунд үе: **дундад эртний үе** (таваас арван тавдугаар зууны үе хүртлэх түүхийн үе); **дундад эртэн** (дундад эртний үе); **дундад найрт яруу хөгжим** х у у ч и р с а н (тэнгэр, газар, сүм тахиж, тариа ургац гуйхад үүсгэх хөгжим): **дундад найрт залгамжлалт хөгжим** х у у ч и р с а н (эзэн хааны сууринд ба ордонд өөд болох зэрэгт үүсгэх хөгжим); **дундад найрт тунгалаг хөгжим** х у у ч и р с а н (дэлгэр их хуримлах, амус дэвшүүлэхэд үүсгэх хөгжим).

ДУНДАЖ ямар нэгэн юмны тоо хэмжээний нийлбэрийг тухайн тоонд хуваах гарсан барагцаа хэмжээ; *жилийн дундаж; дундаж цалин; дундаж хурд; хүн нэгбүрт дунджаар оногдох нь.*

ДУНДАХЬ дунд буй юм; *дундахь байшин; дундахь ширээ; модны дундахь халз.*

ДУНДГУЙ 1. өнхрүүлэх дугуй юм; 2. хүүхэд дугуй юмыг өнхрүүлэхдээ өгүүлэх аялга; *дундгуй!;* 3. хүүхэд нэг савтай юмыг харилцан ээлжлэн амсах дутамд өгүүлэх аялга.

ДУНДГУЙЛАХ 1. дугуй юмны өнхрөх; 2. хүүхэд багачууд, нэг савтай юмыг харилцан ээлжлэн идэх уух; *аягатай сүүгээ дундгуйлж уух.*

ДУНДДАХ дундуурдах, хэтэрхий дунд болох.

ДУНДДУУЛАХ дунддахын үйлдүүлэх хэв.

ДУНДЛАХ 1. дунд болгох, дүүрэн биш болгох; 2. дундыг барих.

ДУНДРАХ дүүрэн байсан юм дунд болох; *аягатай ус ширгээд дундарчээ.*

ДУНДРУУЛАХ дундрахын үйлдүүлэх хэв.

ДУНДТАХ улам хүнд болох.

ДУНДУУР 1. голоор, төвөөр, хоорондуур; *олон гэрийн дундуур гарч ирэв;* 2. дотуур; *усан дундуур туулав; элсэн дундуур явсаар байгаад төөрөлдөв;* 3. дунд, үеэр; *шуурган дундуур урууддан малын хойноос явцгаав; ажлын дундуур үймүүлэв: нойр дундуур сэрээв;* 4. дүүрэн биш; *дундуур аяга цай; дундуур дундуур гэсээр долоон дундуур болгох* хууч; 5. шилжсэн *барагтайхан, дульхан; түүний бичсэн юм сананд их л дундуур байна билээ;* 6. юмны тал хувь; *хагас дундуур; нэгэн дундуур; тэхий дундуур.*

ДУНДУУРДАХ нэндүү дундуур болох.

ДУНДУУРЛАХ 1. дундуур болгох, 2. шилжсэн хагаслах, хагаст хүргэх, хагасыг өнгөрүүлэх; *сар дундуурлаад явжээ.*

ДУНДУУРХАН баахан дундуур; *дундуурхан хийгээд өгөөрэй.*

ДУНИАРАХ 1. салхигүй, дулаан тогтуун байх; *дуниарсан сайхан өдөр;* 2. шилжсэн залхуу хүрч, нүд талмиатаж байх; *нүд дуниарах.*

ДУНИГАНАХ дунигар юмны үргэлжлэн хөдлөх.

ДУНИГАР хээнцэр, чамин байдалтай.

ДУНИЙХ дуних.

ДУНИЛЗАХ дунигар юмны байн байн хөдлөх.

ДУНИХ 1. дунигар болох; 2. шоодсон гоёж хээнцэрлэн энэ тэр газраар явах, *хаагуур дуньж яваад ирэв, та?*

ДУНХАЙЛГАХ дунхайхын үйлдүүлэх хэв.

ДУНХАЙХ дунхгар болох.

ДУНХАЛЗАХ дунхгар хүний хээнцэрлэн хөдлөх, аашлах; *дугуй малгай духдуулж тавиад дунхалзаж явна билээ.*

ДУНХАЛЗУУЛАХ дунхалзахын үйлдүүлэх хэв.

ДУНХГАНАХ дунхгар юмны үргэлжлэн хөдлөх.

ДУНХГАР төв аятай, том тохьтой; *дунхгар гэр.*

ДУНШАА дунших үйлийн нэр; шийдвэргүй; *дуншаа хүн.*

ДУНШИХ тулгуурлахгүй эргэлзэх, тээнэгэлзэх, шийдвэрлэж чадахгүй болох; *тэргуай ч ямар ч шийдвэргүй дуншиж л байгаа биз;* **дуншиж өвдөх** (а. жирэмсэн хүний бие эвгүйдэж бага зэрэг өвдөх; б. архагшсан өвчний байн байн хөдөлж, зөөлөн өвдөх).

ДУНШМАЛ дунших үйлийн нэр; *шийдвэртэй юм хэлдэггүй дуншмал болсон хүн; дуншмал өвчин.*

ДУР 1. хүсэл, дуршил, тааламж; **хүсэл дур, дур хүсэл, хайр дур, янаг дур** хорш.; **дур булаах** (дур нь өөрийн эрхгүй хүрэх): **юу сайхан, дур сайхан** (өөрийн санасан, өөртөө зөв); **муу дур нь хөдлөх** (муу ааш нь хөдлөх); **шары нь авахаар дуры нь ав** (бусдын санаа сэтгэлийг биедээ татах аргыг хэрэглэ), **дур дарах** (хүссэн санасныг баахан хангах); **дур ханах** санаа хүсэл сэтгэлчлэн гүйцэх); **дур хүрэх** (аливаа юманд бахдах хүсэх): **дур гутах** (дургүй хүрэх); **дур болих** (дургүй хүрэх); **дуран дээр хясах** (дурлан атлаа хоосоор болох ба болгох); 2. зоригоороо; санаагаараа, бодсоноороо; **дур зориг** хорш.; *дурааараа аашлах; дурааараа авах; дурааараа сэлгүүцэх; дураар нь тавих; дурааараа загнах; дур дурааараа; өөр өөрийн дураар; дур зоригоороо; амныхаа дураар; санааныхаа дураар; дурааараа: болог;* ☆ **сайн дурын байгууллага** (хүсэлээр нь элсүүлэн авах байгууллага); **сайн дурынхан** (сайн дураар элсэгчид); **дур зоригийн хээлтүүлэг** (хээлтэгч, хээлтүүлэгч малыг нийлүүлж зоргоид нь хээлтүүлэх арга).

ДУРАВЛАГ ургамал үет ургамлын язгуур, бут бутаар ургадаг түрүүт өвс, малд тэжээлтэй, төрөл зүйл олон.

ДУРАЙЛГАХ дурайхын үйлдүүлэх хэв, дурайхад хүргүүлэх.

ДУРАЙХ тов тодорхой харагдах; *гэрэл зураг дээр тов тодорхой дурайн харагдаж байв.*

ДУРАЛ 1. зориг, дур; 2. бага хүүхэд бусдаар түрээ барих зан.

ДУРАМЖХАН төдий л дуртай биш; *дурамжхан хөдлөв.*

ДУРАМЧХАН дурамжхан.

ДУРАН I хүсэл, дурлал; *дуран дээр нь хясах.*

ДУРАН II холын юмыг харах хараа зүйн хэрэгсэл; *хоёр нүдний дуран; зөрүү хараат дуран: дуран хараатай буу;* **дуран авай** (оргторгуйн одон гаргийг харахад хэрэглэх дуран).

ДУРАНБАЙ нүдээр харах аргагүй бичил зүйлийг харах шил бүхий дуран, дуран авай; *бичил дурангаар харах.*

ДУРАНДАХ дурангаар харах.

ДУРАНДУУЛАХ дурандахын үйлдүүлэх хэв.

ДУРВАГАНАХ галын хөгжин шатах; *галын дөл дурваганах.*

ДУРГАН дутуу, цөөхөн, хүрэлцээ муутай; дутуу **дурган** х о рш . .

ДУРГИХ дур зоргоор аашлах; *дураараа дургиж, дунд чөмгөөр гишгэх* х у у ч .

ДУРГҮЙ санаанд нийлэмжгүй, дур дурлал орохгүй; *хоолонд дургүй;* **дургүй хүрэх** (а. юманд үл дурлах; б. ямар нэгэн юмыг үл тааламжлах); **дургүйд хүчгүй** (эрхбиш хүний дуры нь харгалзах нь чухал); **дургүй ламд дарж байж сахил өгч болдоггүй** (дургүй л бол, тушаагаад ч тусгүй); **дур дураа голохгүй, дунд чөмөг сүүжээ голохгүй** (өөрийн санасан бодсоныгоо өөрөө зөв гэж итгэдэг).

ДУРГҮЙЦЭЛ дургүйцэх үйлийн нэр; *олны дургүйцлийг хүргэв.*

ДУРГҮЙЦЭХ 1. дургүй хүрэх; 2. цааргалах, татгалзах; *би дургүйцэхгүй.*

ДУРДАН нэгэн зүйл торгомсог барааа; *дурдан шаа: бажгир дурдан; чинчүү дурдан; шангийн дурдан.*

ДУРДАТГАЛ дурсамж болгон бичсэн хэлсэн зүйл; *дурдатгал яриа; дурдатгалын түүвэр.*

ДУРДАХ дурьдах.

ДУРДУУЛАХ дурдахын үйлдүүлэх хэв.

ДУРДХИЙХ маш түргэн явах, давхийх.

ДУРЖГАНАХ дужигнах; *дуржганатал харуулав.*

ДУРЖГАНУУЛАХ дуржганахын үйлдүүлэх хэв.

ДУРЛАЛ 1. дурлах **үйлийн** нэр; дуршил, эгээрэл; 2. тэсгэлгүй хайрлан дотночлох сэтгэл; *хайр дурлал.*

ДУРЛАМ дурламаар, хүсмээр.

ДУРЛАМААР дур хүрмээр, бахдам; *дурламаар сайхан юм олон байдаг*

ДУРЛАСХИЙХ баахан дурлах; *анхандаа дурласхийгээд, дараа нь ухарчээ.*

ДУРЛАХ 1. юманд бахдаж дур хүрэх, сэтгэл тэмүүлэх; *дурламаар сайхан хувцас;* 2. янаг сэтгэлтэй болох; *хүүхэнд дурлах;* 3. өө сэв эрэлхийлэх; *хэрэгт дурлах.*

ДУРЛУУЛАХ дурлахын үйлдүүлэх хэв, дуртай болгох.

ДУРМАГЧ дуртай биш, дурлал муутайхан.

ДУРМАГЧХАН арай дурмагч; *дурмагчхан авлаа.*

ДУРМАС бөө удирдагчийн хэрэгсэл.

ДУРС өвс модны гадаад хальс.

ДУРСАЛ дурсах үйлийн нэр; дурсалгүй *өнгөрөв.*

ДУРСАМ дурсмаар.

ДУРСАМЖ нэхэн дурсаж хоцроосон юм; *дурсамж бичиг.*

ДУРСАХ 1. дурдан санах, дурдах; *нас нөсцсөн баатрыг дурсан санав;* 2. нэгэн удаа хэлэх, сануулах; *би эртээр дурсаж байсан; түүний тухай чамд юу ч дурссангүй.*

ДУРСГАЛ 1. ач гус, найр нөхөрлөлийн илэрхийлэл; *дурсгалын хөшөө; дурсгал болгон үлдээх; дурсгалын хурал; дурсгалын тэмдэг; дурсгал болгох;* 2. өнгөрсөн үеийн өв соёлоос үлдсэн зүйлс; *бичиг дурсгал; эдийн дурсгал; хөшөө дурсгал;* 3. дуртгал.

ДУРСГАХ дурсгал болгох; *дурсгаж өгөх; ном дурсгах.*

ДУРСГУУЛАХ дурсгахын үйлдүүлэх хэв.

ДУРСЛАХ модны хальсыг хуулж арилгах.

ДУРСУУЛАХ 1. дурсахын үйлдүүлэх хэв; 2. дурсагдах.

ДУРТАЙ дур бүхий, хүсэлтэй, таалалтай; *дуртай юмаа авах; дуртай ажлаа хийх; дуртайяа зөвшөөрнө; дуртайяа хүлээнэ; бид хоёр харилцан дуртай; ном унших дуртай;* **дуртай дургүй** (дур саналыг үл хайхрах; *дуртай дургүйг асуухгүй, тушааж байна, чамд).*

ДУРТГАЛ мэдэж өнгөрснийг нэхэн санах *санаа; Сүхбаатарын дуртгал; дуртгал бичиг; дуртгал яриа.*

ДУРТГАХ өнгөрсөн хэрэг явдлыг дурсан сануулах; *дуртгаж хэлэх; дуртган тэмдэглэх.*

ДУРШИЛ 1. дурлаж хүсэх зүйл; 2. юм идэхийг хүсэх хүсэл.

ДУРШИХ дурлах шинжтэй болох, дур урам орох.

ДУРЬТАХ 1. өнгөрсөн үйл явдлыг дурсан хэлэлцэх буюу илтгэн сэтгэх; 2. аливаа хэрэг юмыг илэрхийлэн бичих, тэмдэглэх, хэлэх; *дээр дурьдсанаас үзэхэд; өнгөрснийг дурьдаж ярихад.*

ДУРЬТГАХ дуртгах.

ДУСААГУУР дусаадаг хэрэгсэл; *нүдний дусаагуур.*

ДУСААЛ шингэн юмны дусал дуслаар гоожсон хэсэг; *борооны дусаал; бар гуай ч яах вэ, дусаал гуай л хэцүү байна гэж эмгэн хэлэв* (үлгэрээс); *далайд дусаал нэмэр* з ү й р.

ДУСААЛГА дусаах юм, хэрэгсэл.

ДУСААЛГАХ дусаахын үйлдүүлэх хэв, дусаахад хүргүүлэх.

ДУСААХ 1. дусахын үйлдүүлэх хэв; *нүдэнд эм дусаах;* 2. юман дээр бага сага юм нэмэх нэмэрлэх; *цай дээр сүү дусаах.*

ДУСАЛ I 1. шингэн юмны жижиг мөхлөгөөр унасан бэөрөнхий хэсэг; *дуслыг хураавал далай болно, дуулсныг хураавал эрдэм болно* х у у ч; 2. хуучин монгол бичгийн цэг; *На-гийн дусал; Га-гийн дусал.*

ДУСАЛ II эр бэлгийн эрхтэнээс гарах бэлгийн үр шим, эс бүхий зүйл, садар ус ч гэдэг.

ДУСАХ шингэн юмны дусал дуслаар гоожих; *модон дээвэр нь ялзарч бороо дусч байв; нулимс дусах.*

ДУСЛАХ байн байн дусах; *бороо дусалж байна; ус дуслах.*

ДУСЛУУЛАХ дуслахын үйлдүүлэх хэв, дуслахад хүргүүлэх.

ДУТААХ I зугтах; оргон дутаах.

ДУТААХ II дутахын үйлдүүлэх хэв, дутуу болгох; *мөнгө дутаах; малаа дутаах.*

ДУТАГДАЛ 1. юмны дутсан нь; *мөнгөний дутагдал; дутагдал бараа;* 2. алдаа; **алдаа дутагдал** х о р ш.; *ажил дээр гаргаж байгаа дутагдлыг арилгахын төлөө чармайх хэрэгтэй.*

ДУТАГДАХ дутахын үйлдэгдэх хэв, дутах; *дутагдаж байгаа* з ү й л; *мөнгөөр дутагдаж явжээ.*

ДУТАГДУУЛАХ дутагдахын үйлдүүлэх хэв; *дутагдуулсан зүйлийг төлж гүйцээх.*

ДУТАХ 1. зохих хэмжээнд хүрэхгүй, дутуу болох, бүрэн биш болох; *сонины нэг дугаар дутав; арван төгрөг дутав;* **аз дутах** (хувь заяа дутах; *миний аз дутаад машинаас хожимдов);* 2. чанараар зохих хэмжээнд үл хүрэх; *энэ аргагүй дутна, хаанаас гүйцэх вэ? яс чанараар дутах; чадлаар дутах.*

ДУТАХГҮЙ 1. үл дутах, үүнээс хэтрэхгүй; *арван төгрөг яасан ч дутахгүй;* 2. тэнцүү, дордохгүй; *би чамаас лав дутахгүй.*

ДУТМАГ 1. дутуухан, дулимаг; *урьд юмаар дутмаг амьдарч байсан ажээ;* **ядмаг дутмаг** х о р ш.; 2. дутуу, бага; *эрдэм чадал дутмаг; эрэлхэг зориг дутмаг.*

ДУТМАГДАХ хэтэрхий дутмаг болох.

ДУТУУ 1. зохих хэмжээ тоонд үл хүрэх; *дутуу мөнгийг төлж гүйцээх болов; дутуу нойртой; есөд арван минут дутуу байна; эрхтэн дутуу; дутуу хуцуу; дутуу дурган;* **дутуу дулим хийх** (хайш яйш хийх); **дутуу тахир** (эрэмдэг зэрэмдэг); 2. гүйцэд биш, бүрэн биш; *хоолоо дутуу идэв; дутуу болсон мах; дутуу харах; дутуу бичих; дутуу бодох;* 3. чанар байдлаар зохих хэмжээнд үл хүрэх, үл гүйцэх; *үзэмжээр дутуу; ясаар дутуу; чадвараар дутуу.*

ДУТУУДАХ 1. хэтэрхий дутуу болох; *чадал дутуудав; эрдмээр дутуудаж байв;* 2. мөчдөх, омтгойдох.

ДУТУУДУУЛАХ дутуудахын үйлдүүлэх хэв.

ДУТУУЛАХ дутахын үйлдүүлэх хэв, дутахад хүргүүлэх.

ДУТУУХАН арай дутуу.

ДУУ (Н) I 1. сонсох эрхтэнд сэрэгдэх авиан чимээ; **дуу чимээ** х о р ш.; *бууны дуу; нарийн дуу; хашгирах дуу; чанга дуугаар хэлэв; тэнгэрийн дуу; зөөлөн дуу; өндөр дуу; дорой дуу; муу хүний дуу их* х у у ч.; **дуу дуугаа авалцах** (харилцан чимээгээ авалцах); **дуу өгөх** (чимээ өгөх); **дуун ухаан** (авиан зүй); **дууны хөвч** (авиа гарах эрхтэн); **дуу хөрвүүлэгч** (х у у ч и р с а н (орчуулагч); **дуу хураагуур** (дуу чимээг соронзон хальсанд буулгах цахилгаан хэрэгсэл); **дуу зэтлэх** (дуу чимээ, бусад юманд дам дам уламжилж цууриатан одох); 2. ш и л ж с э н үг, яриа; **дуу цөөнтэй хүн** (үг цөөнтэй, ам удаантай); **дуу шуу болох** (үймэн шуугих); 3. дуулахад зориулсан шүлэглэмэл зохиол; *ардын дуу; үетэн дуу; жагсаалын дуу; түүхэн дуу; янаг амрагийн дуу; дөрвөл дуу; богино дуу; бүжгийн дуу; найрын дуу; харилцаа дуу;* **дуу гарах** (а. дуу аялж эхлэх; б. дуу зохиох; в. чимээ гаргах).

ДУУ II доо, хутга сэлэм зэргийн ишний үзүүрт углах төмөр; *жадны дуу.*

ДУУГАЙ 1. олон таван үггүй, олон үг ярьдаггүй; *дуугай хүн;* 2. үг ярих хэлэхгүй, дугай суух; **дуугай бай!** (чимээгүй).

ДУУГАРАХ дугарах I.

ДУУГАРУУЛАХ дуугарахын үйлдүүлэх хэв.

ДУУГИХ 1. шавхийх, гавшгай шаламгай хөдлөх; *дуугисан залуу байна, ажиллаад байя даа;* 2. түвшин, эетэй байх; *дуугитал унтах; дуугитал явдаг морь.*

ДУУГҮЙ 1. дуугай, дуугардаггүй, олон таван үггүй; *дуугүй суух; дуугүй хүн;* 2. дуу чимээгүй, бага буюу муу дуутай; *дуугүй бороо; дуугүй хонх;* **үг дуугүй** (хэл амгүй, тайлбар ярнагүй; *үг дуугүй зөвшөөрөх; үг дуугүй хүлээх; үг дуугүй дагалдах);* **дуугүй гийгүүлэгч** (егүүлэхэд дууны хөвч үл доргих гийгүүлэгч).

ДУУДАХ 1. нааш ир гэж дугарах, дугаран нааш нь оӣртуулах; *сурагчийг багш нь дуудав; холоос дуудах; утсаар дуудах;* 2. өндөр дуугаар өгүүлэх; *бичиг дуудах; морины цол дуудах; үнэ дуудан худалдах;* 3. худалдах юмны жинхэнэ өгөх үнийг шууд хэлэхгүй, илүү үнэ хэлэх; *та худалдах гэж байгаа бол битгий дууд, өгдөг үнээ хэл, би авъя;* 4. уриалах; **уриалан дуудах** х о р ш..

ДУУДЛАГА дуудах үйлийн нэр; *дуудлага явуулах; дуудлагын тэрэг; зөв дуудлага;* **бөөгийн дуудлага** (онгод урих, даатгахад хэлэх үг): **утга зохиолын хэлний дуудлагын хэв журам** (зөв дуудах ёс).

ДУУДРАМ хөгжмийн зэвсэг, жаазанд бэхэлсэн олон тооны дугуй төмөрлөг, цохиж эгшиг оруулна.

ДУУДУУЛАХ дуудахын үйлдүүлэх хэв, дуудахад хүргүүлэх.

ДУУЛАЛ 1. зохиолын хэлбэр, аялгуу авч уншихад зориулан үгний урт охрыг бодохгүй тааламжтай үгсээр найруулан бичсэн зохиол; 2. дуу; **төрийн дуулал** (төр улсын мандан бадрахын бэлэгдэл болгосон албан ёсны хүндэтгэлийн дуу); **намын дуулал** (ангийн нэгдэл нягтралын бэлэгдэл болгосон хүндэтгэлийн дуу): **дуулал бүжиглэл** (олноороо дуулан бүжиглэх бүжиг).

ДУУЛАМ дуулмаар.

ДУУЛАХ I дуу эгшиглэх, аялах; *дуу дуулах; хоолой нийлүүлэн дуулах.*

ДУУЛАХ II сонсох; *дуулж бай!; тийм гэж би дуулсан; нэг чихээр дуулаад нөгөө чихээр гаргах.*

ДУУЛГА 1. урьдын баатруудын байлдаанд өмсч байсан төмөрлөг малгай; 2. нойжингийн өмсөх малгай.

ДУУЛГАЛАХ дуулга өмсөх.

ДУУЛГАР үг сургамж авдаг; *дуулгар сайтай; дуулгар муутай.*

ДУУЛГАРГҮЙ үг зааварт орохгүй зөрчимтгий; *дуулгаргүй амьтан.*

ДУУЛГАРТАЙ үг сургаал авамтгай; *дуулгартай явах.*

ДУУЛГАХ сонсгох, мэдэгдэх; *энэ учрыг танд дуулгая.*

ДУУЛДАХ сонсдох, сонсч мэдэх, сонсогдох.

ДУУЛИА дуулиан.

ДУУЛИАН 1. цуурай; *хадны дуулиан;* 2. ш и л ж с э н үг цуурхал, дамын сүртэй үг чимээ; *хоосон дуулианаар сандарчээ.*

ДУУЛУУЛАХ дуулах I-ийн үйлдүүлэх хэв.

ДУУНИХ дугууних.

ДУУРАМ 1. зуурсан юмны нийц сайтай; *дуурам сайхан тараг;* 2. ш и л ж с э н зөөлөн явдалтай; *дуурам явдалтай морь.*

ДУУРАХ I яг ёсчлон дуурнах.

ДУУРАХ II нуурах, нийцэх; *айраг дуурталбүлэх.*

ДУУРВИЛ чухал; *дуурвилд үзэх авах.*

ДУУРИАЛ дуурнах үйлийн нэр, үлгэр жишээ болговол зохих юм; **үлгэр дуурнал** х о р ш.; *дуурнал болохуйц зүйлийг бүтээх хэрэгтэй.*

ДУУРИАЛАХ дуулиан гаргах, цуурналах.

ДУУРИАЛГА дуурнал.

ДУУРИАЛГАХ дуурнахын үйлдүүлэх хэв, дуурнахад хүргүүлэх, үлгэр жишээ болгуулах.

ДУУРИАМГАЙ дуурнах зантай.

ДУУРИАМТГАЙ дуурнамхай.

ДУУРИАМХАЙ дуурнамтгай .

ДУУРИАН анир чимээ, цуурай.

ДУУРИАХ 1. адил болох; *эхийгээ дуурнасан хүүхэд; чи намайг дуурнаж хөдөл!;* 2. үлгэрлэж мөрдөх, жишээ болгох; *дуурнавал зохих жишээ; дагаж дуурнавал болох зүйл.*

ДУУРИЛАХ дуурь гаргах, дуурь наадах, жүжиглэх, бүжиглэх.

ДУУРМАГ ингэний сүүгээр хийсэн идээний нэр; *дуурмаг уугаад маш их хөлрөв.*

ДУУРЬ дуулалт жүжиг, театрт тоглох аялгуут драмын зохиол, мөн тоглогчид нь хөгжмийн аяар дуулах жүжиг; *«Жаргалын зам» гэдэг дуурь; дуурьд тоглох; дуурийн жүжигчин; дуурийн театр; үндэсний дуурь; дуурь үзэх.*

ДУУРЬСАХ олноо алдарших, цуугин хэлэлцэх **болох**; *тэргүүний ажилчны нэр олон даяарт дуурьсав.*

ДУУРЬСГАЛ цуу, алдар; *дуурьсгалт баатар; алдар дуурьсгалыг цуурайтуулах.*

ДУУРЬСГАХ дуурьсахын үйлдүүлэх хэв, олонд алдаршуулах.

ДУУСАН тухайн үе, цагийн турш; *жил дуусан; өдөр дуусан; шөнө дуусан нойргүй суув.*

ДУУСАХ 1. гүйцэх, төгсөх; *барилгын ажил дууссаны дараа; сар дуусмагц; хугацаа дуусах;* 2. гүйцээх, барах; *ажил хийвэл дуустал, давс хийвэл уустал зүйр;* 3. шувтрах, гүйцэх, барагдах; *давс дуусчээ; зуухан дахь гал ноцож дуусав.*

ДУУСВАР дуусгал, төгсгөл.

ДУУСВАРЛАХ дуусах, төгсөх.

ДУУСГАЛ дуусвар.

ДУУСГАР төгсгөл, дуусвар.

ДУУСГАРГҮЙ дуусах цаггүй.

ДУУСГАХ дуусахын үйлдүүлэх хэв, дуусахад хүргүүлэх; *ажлаа дуусгах.*

ДУУСГУУЛАХ дуусгахын үйлдүүлэх хэв.

ДУУТ дуу бүхий; **дуут шувуу** амьтан (шөнө дуугарна, бие үзэгдэхгүй, дуу нь сонсдодог нэгэн зүйл шувуу); **дуут цадуулай** амьтан (толгой хүзүүндээ хар бидэртэй, зажуур цагаан, жигүүр сүүл хөх, жигүүрийн үзүүр цагаан, шөнө турш дуугардаг шувуу); **дуут болжмор** (гуа болжморын өөр нэр); **дуут гурил** (төмсний гурил).

ДУУТАЙ 1. дуу гардаг; *дуутай кино;* 2. дуу ихтэй, дуу сайтай; *дуутай бороо усгүй, цуутай хүүхэн хуримгүй* зүйр; **дуутай шуутай** хорш.; **дуутай гийгүүлэгч** (өгүүлэхэд дууны хөвч доргих гийгүүлэгч).

ДУУЧ (ИН) дуулах мэргэжилтэй хүн; *сайн дууч;* ☆ **дууч** эм хуучирсан (янхан).

ДУХ 1. хуучирсан толгойн орой дагз хоёрын хоорондох түнтгэрхэн хэсэг газар; 2. магнай зулайн орчин газар; **дух'цох** хорш.; *дух дээр нь унсэв.*

ДУХАЙЛГАХ духайхын үйлдүүлэх хэв.

ДУХАЙХ духгар болох.

ДУХАХ 1. хувцас хунар дөнгөж багтах; *энэ гутал над духахгүй;* 2. дөнгөж хүрэлцэх; *цамцад хоёр метр даавуу арай л духав; хаалгаар духахгүй том ачаа;* 3. хугацаандаа дөнгөж багтах; *арай чамай духаж ирлээ.*

ДУХГАР урагшаа өцгөр бөхгөр; *духгар гэр.*

ДУХГАРДАХ хэтэрхий духгар болох.

ДУХДАХ дух дээр нь цохих, цохдох.

ДҮГДРЭЛ дүгдрэх үйлийн нэр.

ДҮГДРЭХ ярих уншихад үг авиаг хэлж чадахгүй гэнэт тасалдах, тээглэх; *сайхан уншиж чадахгүй дүгдрээд байх юм.*

ДҮГДРЭЭ дүгдрэх заншилтай; *дүгдрээ хүн.*

ДҮГДЧИХ байн байн дүгдрэх .

ДҮГНҮҮЛЭХ дүгнэхийн үйлдүүлэх хэв; *ажлаа дүгнүүлэх.*

ДҮГНЭЛТ дүгнэх үйлийн нэр; 1. ерөнхий нийлбэр, дүн; 2. хураан бодож олсон баталгаа; *сонин дүгнэлт; зөв дүгнэлт; тодорхой дүгнэлт хийх.*

ДҮГНЭХ дүгнэлт хийх; *орлого зарлагын данс дүгнэх; ажлын явцыг дүгнэх.*

ДҮГРЭГ дугариг, дугуй; *дүгрэг сар; дүгрэг малгай.*

ДҮГРЭГЛЭХ 1. дүгрэг болгох; *сар дүгрэглэх;* 2. шилжсэн хүрээлэн хасах, хаах; *данс дүгрэглэх.*

ДҮГРЭХ тойрон эргэх; *тээрмийн илжиг дүгэрсээр байв.*

ДҮГЭХ дүгэх дүлий ташаа сонсох дүлий.

ДҮД шашин шашны үйлстэнд саад хор хүргэгч; *дүд болох; дүд орших.*

ДҮДЛЭХ дүд болох, хор саад болох, болгох.

ДҮДНЭХ аман дотроо үглэх; **дүднэн даднан ярих** (хүүхдийн сая хэлэнд орох).

ДҮДНЭЭ дүднэх заншилтай; *дүднээ хүн.*

ДҮДТЭХ хор саад учруулах.

ДҮДЭГЛЭХ хөтөх шувууны дуугарцгаах.

ДҮДЭГНЭХ аман дотроо ярьсаар цөвтнөн ажил хийх; бэвтнэн хөдлөх; *дүдэгнэсэн сүрхий өвгөн билээ.*

ДҮЖИГНҮҮЛЭХ дүжигнэхийн үйлдүүлэх хэв.

ДҮЖИГНЭХ торжигнох чимээ сонсдох; *тэрэг дүжигнэх; олон амьтны хөлийн чимээ дүжигнэв; чих дүжигнэх.*

ДҮЗЭМ у р г а м а л халуун орны уул завт ургадаг нэгэн зүйл модноос гарна, цэцэгтэйгээ 8-р сард боловсроно, өндөгний мэт их, амт хүчтэйхэн нэгэн зүйл жимс.

ДҮЙ эв, эе, ур; *эв дүйгий нь олох; гартаа дүй муутай.*

ДҮЙВҮҮЛЭХ 1. дүйвэхийн үйлдүүлэх хэв; 2. булзааруулах, замхруулах, дүйвээн шуугианаар далимдуулан өнгөрүүлэх; *дүйвүүлж байгаад мэдэгдэхгүй өнгөрөхийг чармайжээ.*

ДҮЙВЭХ олны хөхөөлд явах.

ДҮЙВЭЭЛЭХ 1. дуунаас дүйвээн гарах; 2 ямар нэгэн юмаар далим шалтаг болгон булзааруулж өнгөрөөх; *ажлаа дүйвээлж өнгөрөв.*

ДҮЙВЭЭН олны дуунаас дам дэгдэн гарах чимээ; *сохор нохой дүйвээнээр, соотон халтар чимээнээр* з ү й р; **дүйвээнд явах** (олны хөхөөлд явах).

ДҮЙВЭЭНТЭЙ чимээ ихтэй, нүргээнтэй; *дүйвээнтэй явдал болж гэнэ.*

ДҮЙГҮЙ юм хум хийхдээ эв хавгүй, ур муутай; *чиний гар яасан дүйгүй хөдлөнө вэ!.*

ДҮЙЗ 1. нэгэн адил, хоёр хос зүйл; **дүйз дүйзээр** (ижил ижлээр); 2. бяцхнаар хэсэглэн овоолсон өвс; *дүйз өвс.*

ДҮЙЗЛЭХ 1. юмыг адил, ижил хос болгох; 2. өвсийг жижиг хэсэг хэсгээр овоолох; *өвс дүйзлэх.*

ДҮЙЛГЭХ дүйхийн үйлдүүлэх хэв, **дүйхэд** хүргүүлэх; *дүйлгэж үзэх.*

ДҮЙНГЭ төрөлхийн ухаан муутай мангуу.

ДҮЙНГЭДЭХ хэтэрхий дүйнгэ байх.

ДҮЙНГЭРЭХ 1. дүйнгэ болох; 2. дөжрөх.

ДҮЙНГЭТЭХ дүйнгэ зан байдал гаргах, тэнэгтэх.

ДҮЙРҮҮЛЭХ дүйрэхийн үйлдүүлэх хэв.

ДҮЙРЭН тэнэг мангуу, дүйнгэ; **дүйрэн өвчин** (дүйнгэ, мангуу болох өвчин).

ДҮЙРЭНБЭ ш а ш и н зурхайн ухаанд мэрэгжсэн хүнд олгох эрдмийн зэрэг, зээрэмбэ ч гэдэг.

ДҮЙРЭНГЭ дүйнгэ.

ДҮЙРЭНДЭХ дэндүү дүйрэн байх.

ДҮЙРЭХ 1. толгой манаран дүнсийж балайрах; *толгойгоо дүйртэл унав;* 2. ш и л ж с э н ухаан санаа самуурах, төөрөгдөх, учрыг олохгүй гайхах; *аль ч учрыг олохгүй дүйрч хоцров.*

ДҮЙТЭЙ юм хум хийх үйлдэхдээ уртай, эе эвийг сайн олдог; *гарын дүйтэй хүн.*

ДҮЙХ I олон тооны юмыг худалдан авах ба өгөхөд сайн муу, их бага зэргийг тус тусад нь харгалзахгүй олноор, нийтэд нь үнэ тогтоож авах ба өгөх; *хөдөөний хүнээс нилээд олон хонь дүйж авчээ.*

ДҮЙХ II 1. юм хийхэд ор нэр болгож хуурамч муугаар хийж өнгөрөхийг хичээх; **дүйх дайх** х о р ш.; 2. дүйз хос болгох, адил ижил болох, харилцан тохирох таарах; *энэ тэр хоёр үнэхээр дүйсэн байна.*

ДҮЛ (ЭН) 1. турш, туж, дуусан; *шөнө дүлэн явав; өдөр дүл хүлээв.*

ДҮЛД б и ч и г эгнэгт, эрхбиш, харин ч; *дүлд тийм ажил хийх хүн биш.*

ДҮЛИЙ I 1. чих огт сонсохгүй буюу муу сонсох; *хоёр чих нь дүлий; таг түлий;* 2. дөжин; **дүлий дөжин, дүлий дүмбэд** х о р ш..

ДҮЛИЙ II: **тэнгэрийн дүлий** бөөрөнхий мөөгөнцөр зүйл, доторхи зөөлөн зүйл нь хатахдаа хар тоос болно.

ДҮЛИЙ III бүдэг, цэхэр, гэрэл муутай; *дүлий шил; дүлий цагаан; дүлий хөх .*

ДҮЛИЙРҮҮЛЭХ дүлийрэхийн үйлдүүлэх хэв, дүлий болгох.

ДҮЛИЙРХЭХ сонссоор атлаа үл сонсогч болон ааашлах.

ДҮЛИЙРЭХ 1. чих сонсохгүй дүлий болох; *өрөвсөн чих дүлийрэв;* 2. дүлий юм шиг байдал гаргах.

ДҮЛИЙХ юмны нэгэн зүг тийш хазайх; *утасны шугамын шон мод зүүн өмнө тийш дүлийсэн байв.*

ДҮЛҮҮЛЭХ I дүлэхийн үйлдүүлэх хэв, дүлэхэд хүргүүлэх.

ДҮЛҮҮЛЭХ II зарим амьтныг гэрийн тэжээвэр болгож халгаан дасгах; *шувуу дүлүүлэх.*

ДҮЛЭР дүлий; **дүлий дүлэр** х о р ш..

ДҮЛЭХ I ямар нэгэн үйл явдал хийхийн тул хэвлийн булчинг чангалан хүчдэх; *төрөхөөр дүлэх; хий дүлэх; өтгөн мөр үзэхээр дүлэх.*

ДҮЛЭХ II 1. үйл ажилд нойр хоолгүй чармайх; 2. шөнийг унтахгүй өнгөрүүлэх.

ДҮМ у р г а м а л уул завт ургана, өндөр нь 3 метр илүү, навч нь туулайн бөөрний хэлбэртэй, цөмөө нь гүйлсний цөмөөтэй адил, цагаан цэцэгтэй нэгэн зүйл мод.

ДҮН I 1. олон тооны нийлүүлсэн товч; *дүн нь 1250 болов; бүгд дүн;* 2. шилжсэн үйл хэргийн дуусгал, үр, боловсрол; *үр дүн; ийм үр дүнтэй болжээ;* **дүндээ** (ердөө, ерөнхийдөө); **дүндээ дүн** (ялгалгүй, адил).

ДҮН II: дүн дан аялга; *жингийн тэрэгний хонх дүн дан хийж байв; дүнзэн мод ч гэсэн дүнтэй дантай байдаг* х у у ч.

ДҮН III ид, хамгийн; *өвлийн дүн хүйтэнд; дүн өвөл; дүн халуун; зуны дүн халуунд.*

ДҮН IV дүн.

ДҮН V: **дүн гуа** у р г а м а л тарвастай адил болоод уртхан, ногоон хальстай нэгэн зүйлийн гуа, чанаж иддэг.

ДҮНБЭ гол төлөв хөлд тохиолдох нэгэн зүйл хүнд өвчний нэр, тулай ч гэдэг; *бөөрний дүнбэ; хөлийн дүнбэ.*

ДҮНБЭТЭХ дүнбэ өвчин тохиолдох.

ДҮНГҮЙ үр ашиггүй; *энэ өдрийн ажил дүнгүй болж өнгөрөв.*

ДҮНГЭНҮҮЛЭХ дүнгэнэхийн үйлдүүлэх хэв.

ДҮНГЭНЭХ чих дүргэлэх бүдүүн болоод удаан дуу гарах; *үйлдвэрийн яндан дүнгэнэв; чих дүнгэнэх; газар дүнгэнэх.*

ДҮНГЭР I бөө нарын хэлтгий хэнгэрэг.

ДҮНГЭР II: дүнгэр дүнгэр алсаас бүдгэвтэр сонсогдох дуу; *дүнгэр дүнгэр ярих.*

ДҮНЗ (ЭН) урт дайрч хөлтөслөн засч чилээсэн бүдүүхэн урт мод; *дүнзэн мод; нарсан дүнз; дүнзэн байшин; засаад дүнз, зүсээд банз.*

ДҮНС тамхины ургамал, гаансанд хийж татна: **ногоон дүнс** (хятад тамхи); **улаан дүнс** (орос тамхи).

ДҮНСГЭР 1. бүүдгэр, бүрхэг; *дүнсгэр өдөр;* 2. шилжсэн муухан ааштай, уруу царайтай; *дүнсгэр царайтай сууж байлаа.*

ДҮНСГЭРДҮҮ дүнсгэр байдалтай.

ДҮНСГЭРХЭН баахан дүнсгэр.

ДҮНСИЙЛГЭХ дүнсийхийн үйлдүүлэх хэв, дүнсийхэд хүргүүлэх.

ДҮНСИЙХ дүнсгэр болох; *тэнгэр дүнсийгээд л байна, бороо орж магадгүй.*

ДҮНТЭЙ дүн бүхий, үр ашигтай, дүн сайтай; *үр дүнтэй ажил хийхэд урамтай байдаг.*

ДҮНЧҮҮР есөн оронтой тоо, зуун сая буюу арван голди.

ДҮНШҮҮР дүнчүүр.

ДҮР 1. дүрс, царай, овор, байдал; **царай дүр, овор дүр, байдал дүр, дүр дүрс** х о р ш.; *бодит дүр; баримал дүр;* 2. утга зохиол урлагт юмны бодит байдал түүний хувь хувийн тодорхой онцлог үзэгдэл, хэлбэрийг уран зохиолын аргаар ерөнхийлөн гаргасан тусгал; 3. хэв шинж, зан төлөв; *уран зохиолд харамч хүний дүрийг гаргах;* **хүний дүртэй** (төлөв томоотой); **дүрээрээ** (уг дүрсээрээ, яг ёсоороо, биеэрээ байгаа; *миний морь дүрээрээ мөн).*

ДҮРВҮҮЛЭХ дүрвэхийн үйлдүүлэх хэв, дүрвэхэд хүргүүлэх.

ДҮРВЭЛГҮЙ сааталгүй, торохгүй.

ДҮРВЭЛЗҮҮЛЭХ дүрвэлзэхийн үйлдүүлэх хэв.

ДҮРВЭЛЗЭХ 1. дүрэлзэх; *гал дүрвэлзэх;* 2. нүд ширүүн хурцаар байн байн харах; *дүрвэлзсэн нүдтэй хүүхэд.*

ДҮРВЭХ дайсан ба хор хөнөөлөөс айж олноороо зайлж буруулах, зугадаж холдох; *дайны хөлөөс дүрвэж уул хаданд гарсан байв.*

ДҮРВЭЭН дүрвэх үйлийн нэр; *дүрвээн болох; дүрвээн дундуур явав.*

ДҮРВЭЭХ дүрвэхийн үйлдүүлэх хэв, дүрвүүлэх.

ДҮРГЭГДЭХ дүйвээнд хөдлөх.

ДҮРГЭЛЭХ доргилох, нүргэлэх, байн байн дүргэх; *чих дүргэлэх.*

ДҮРГЭХ I 1. доргих; 2. олон амьтны дүрхрэх чимээ гарах.

ДҮРГЭХ II усны тойрон эргэх, эргэлдэх; *голын ус дүргэх.*

ДҮРГЭЭН нүргээн, сүртэй; *дүргээнтэй чимээ; дүргээнтэй явдал.*

ДҮРДХИЙХ цочмог хөдлөх; *дүрдхийн босов; ятуу дүрдхийн нисэв.*

ДҮРЛИЙЛГЭХ дүрлийхийн үйлдүүлэх хэв.

ДҮРЛИЙХ дүрлэгэр болох; *дүрлийн харж байв.*

ДҮРЛЭГНЭХ дүрлэгэр амьтны дүрлэг дүрлэг хийх; *дүрлэгнэсэн сайхан нүдтэй.*

ДҮРЛЭГЭР сормуус хөмсөг ихтэй; том бүлтгэр нүдтэй; *дүрлэгэр нүдтэй.*

ДҮРЛЭЛЗЭХ дүрлэгэр амьтны дүрлэс дүрлэс хийх.

ДҮРС 1. юмны хэлбэр маяг, дүр төлөв; **хэлбэр дүрс** х о р ш.; *дүрсээр нь таних; нүдэнд нь их модтой уулын дүрс харагдав;* 2. юмыг дууриалган хийсэн баримал буюу зураг, хөрөг; *Сухбаатарын цэвэр дүрс;* 3. ш и л ж с э н төлөв, зан байдал; *дүрс төлөв сайтай.*

ДҮРСГҮЙ 1. тогтсон хэлбэргүй; *дуу, үнэр, амт, хүртэхүй бол дүрсгүй юм;* 2. ш и л ж с э н томоогүй; зүггүй, төлөвгүй; *дүрсгүй хүүхэд*

ДҮРСГҮЙДЭХ хэтэрхий дүрсгүй болох.

ДҮРСГҮЙТЭХ дүрсгүй зан байдал гаргах.

ДҮРСГҮЙХЭН баахан дүрсгүй.

ДҮРСЛЭЛ дүрсэлсэн юм; *дүрслэл сайтай.*

ДҮРСЛЭХ 1. юмыг дүрслэн үйлдэх; *морь дүрслэх; дүрслэх урлаг; дүрслэн гаргах;* 2. юмны дүрс байдлыг дууриах, мөрдөх; *адил болъё гэж дүрслэх.*

ДҮРСТЭЙ 1. дүрс хэлбэртэй; *зааны дүрстэй;* 2. юмны овор байдал адилхан, ойр төсөөтэй; 3 .ш и л ж с э н хүний байдал явдал түвшин аятай, томоотой; *дүрстэй явах хэрэгтэй.*

ДҮРСТЭЙХЭН баахан дүрстэй.

ДҮРСХИЙХ цочмог үүсэх; *гал дүрсхийх; уур дүрсхийх.*

ДҮРҮҮЛЭХ 1. дүрэхийн үйлдүүлэх хэв; 2. дүрэгдэх.

ДҮРХРҮҮЛЭХ дүрхрэхийн үйлдүүлэх хэв.

ДҮРХРЭХ 1. дүйвээнд доргих; *дүрхрэх чимээ гарав;* 2. олны гэнэт хөдлөх, цуугих; *дүрхрэн хэлэлцэх.*

ДҮРШИХ дүр орох шинж байдалтай болох.

ДҮРШҮҮЛЭХ дүршихийн үйлдүүлэх хэв.

ДҮРЭВЧ I бороо усанд өмсөх гутал шааврын уланд хадсан мод.

ДҮРЭВЧ II юм хум хийж ардаа үүрэглэн явахад тохируулан хийсэн үүргэвч сав; **үүрэг дүрэвч** х о р ш..

ДҮРЭЛЗҮҮЛЭХ дүрэлзэхийн үйлдүүлэх хэв.

ДҮРЭЛЗЭХ гэнэт бадран үүсэх; *гал дүрэлзэх; уур дүрэлзэх;* 2. дүрвэлзэх.

ДҮРЭМ 1. ямар нэгэн юмны хэм жүрмээр тогтоосон заавар, тогтоол; **дүрэм заавар, хууль дүрэм** х о р ш.; *дүрмийн ёсоор гүйцэтгэх; гудамжны хөдөлгөөний дүрмийг баримтлах; нийтээр дагаж мөрдвөл зохих дүрэм;* **дүрэм үзэмж** (дууриал, цээрлэл болгох юм); 2 .ямар нэгэн үзэгдлийн зүй тогтоол, байнгын харьцааг үзүүлсэн байдал; *үсгийн дүрэм; хэлний дүрмийг дагах;* 3. сүрхий, маяг, сүр; **дүрэм үзүүлэх** (сүр болох, сүрлэхэх); **дүрэмтэй хүн** (маяг сүр ихтэй хүн); 4. хэвшиж нэгэнт заншсан ёс журам; *хэв дүрмээс гажих;* 5. юмны дүр дүрс, төрх, төлөв байдал; *дүрэм дүрс; байдал дүрмийг дагах.*

ДҮРЭМГҮЙ 1. журам горимгүй; *дүрэмгүй хэрэг; дүрэмгүй явдал;* 2. дүрс төлөв зэхий; *дүрэмгүй хүн.*

ДҮРЭМДҮҮЛЭХ дүрэмдэхийн үйлдүүлэх хэв.

ДҮРЭМДЭХ дүрэм үзүүлэх, сүр үзүүлэхэ *баахан дүрэмдэж байгаад явжээ.*

ДҮРЭМЛҮҮЛЭХ дүрэмлэхийн үйлдүүлэх хэв.

ДҮРЭМЛЭХ 1. юмыг дүрэмд нийцүүлэх, дүрэмтэй болгох; 2. юмыг мөрдөн дууриах, дагах; 3. дүрэмдэх, сүрдүүлэх; 4. бусадтай адил болохыг хүсэн хичээх.

ДҮРЭМТ дүрэм бүхий; *дүрэмт малгай;* **дүрэмт хувцас** (ёслол жагсаалын хувцас); ☆ **дүрэмт сав** (огторгуйн байдал, уур амьсгал

цаг мөчийг үзэх, хол ойр өндөр богиныг хянахад хэрэглэх багаж хэрэгслийн ерөнхий нэр).

ДҮРЭМТЭЙ дүрэмт; *дүрэмтэй хүн; заавар дүрэмтэй хэрэг.*

ДҮРЭМЧ 1. дүрэмд мэрэгжсэн хүн; 2. дүрэм үзүүлэгч.

ДҮРЭХ I юмыг зарим юманд оруулах, хийх: *хуруугаа усанд дүрэх; цайд талх дүрэх; гурилд мах дүрэх.*

ДҮРЭХ II 1. хутга мэсийг хуйд хийх; *хутгаа хуйд нь дүрэв;* 2. шовх мэсээр чичих, бүлэх: *шөвгөөр бүдүүн гуя руу нь дүрж орхисон байв.*

ДҮРЭХ III орох, оролцох; *бусдын хөрөнгөнд хуруу дүрж болохгүй; хушуу дүрэх; гар дүрэх.*

ДҮҮ I насаар дутуу, ах биш; *надаас дүү хүн; тэр гуайгаас би арав дүү; манай эхийн дүү ирэв; миний бага дүү;* **ах дүү** х о р ш.. *ах нь сургаж дүү нь дагадаг* х у у ч.

ДҮҮ II будаа тариа хэмжих сав, арван шин: *дүү будаанаас шин аага гарна.*

ДҮҮГҮҮНЯН у р г а м а л өвсөн иштэй, өнгө улаан, амт хүчтэйхэн, бүрээслэсэн арьстай, интороос ихээхэн; үр үлэмж нэгэн зүйл жимс.

ДҮҮГҮҮР чулууг үсэргэн шидэх зэвсэг; *гартаа дүүгүүр барьсан хүүхэд явлаа.*

ДҮҮГҮҮРДЭХ 1. дүүгүүрээр шидэх; 2. бөхийн мэх (хоёр мөрнөөс барьж эргүүлдэн хүчдэн савж унагаах).

ДҮҮГЭХ 1. юмны чимээ удаанаар нүргэлэн гарах; *дүүгэж дуугарах;* 2. долгин хөнгөн, хөөрүү хүний ийн тийн болгоомжгүй аашлах; *дүүгээд, ярьж хэлэлцэж болдоггүй хүн.*

ДҮҮДИЙ дүү минь; *дүүдий цаад номоо аваад ир!.*

ДҮҮДЭЭРХЭХ дүүдээрэх байдал гаргах.

ДҮҮДЭЭРЭХ эндүүрэх, ташаарах, самуурахад хүрэх.

ДҮҮЖИГНЭХ 1. өндрөөс унжсан юмнаас дүүжлэгдэн унжих; *олсноос дүүжигнэн тогтож байжээ; дүүжигнэн буух;* 2. ш и л ж с э н бусдыг дагалдаж бараадан арай бүр хоцрохгүй явах; *дүүжигнэсээр байгаад хүрч иржээ;* 3. ш и л ж с э н арай ядан амьдрах; *амь дүүжигнэж байжээ.*

ДҮҮЖИН I 1. дөрөөлж гарах оосор; *өндөр хаднаас унжуулсан дүүжин олс;* 2. өндөр моднооос унжуулсан оосор мэт зүйл, дүүжигнэн савлаж наадах зэвсэг; *дүүжин дээр тоглох;* 3. дүүжилдэг юм; *дүүжин ор; дүүжин өлгий;* **дүүжин үлүүр** (баганат жигнүүр); **дүүжин урхи** (шилүүс агнах хэрэгсэл; уулын хярыг хашин хааж, газар газарт амсар үлдээж дээсний урхид гувж хийлгэж үлдээсэн амсрын тушаа зүүнэ, үүнд шилүүс торвол дүүжлэгдэнэ); 4. шагаа харвахад хоёр багийн нэг нь хожих буюу эсвэл нөгөө нь харьцахын тул харвах эцсийн ганц маш жижигхэн хасаа; *дүүжин харвах.*

ДҮҮЖИН II: **дүүжин даажин** дүүжигнэн наадахад өгүүлэх аялга.

ДҮҮЖЛҮҮЛЭХ 1. дүүжлэхийн үйлдүүлэх хэв; 2. дүүжлэгдэх.

ДҮҮЖЛҮҮР юм дүүжлэх хэрэгсэл; *дүүжлүүр мод.*

ДҮҮЖЛЭГДЭХ I. дүүжлэхийн үйлдэгдэх хэв; 2. ш и л ж с э н маш гачигдан цухалдах.

ДҮҮЖЛЭХ өлгөх, зүүх, унжуулан тогтоох; *хадааснаас дүүжлэх; дэнлүү дүүжлэх; модноос дүүжлэх; дүүжлэн алах.*

ДҮҮЖМЭГ үл хөдлөх цэгээс дүүжлэгдэн унжиж ганхан хөдөлдөг юм; *цагны дүүжмэг; чигийн дүүжмэг.*

ДҮҮЛГЭР хөнгөн болгоомжгүй, хөөрүү, сагсуу; **үүлгэр дүүлгэр** х о р ш.; *дүүлгэр хүн.*

ДҮҮЛГЭРДЭХ хэтэрхий дүүлгэр болох.

ДҮҮЛГЭРЛЭХ дүүлгэр байдал гаргах.

ДҮҮЛЛЭХ 1. хүнийг эчнээ, нүд далд муутган шүүмжлэх; 2. байн байн дүүлэх.

ДҮҮЛЭХ I 1. амьтны нэгээс нөгөөд харайх, дэгдэх; *хэрэм, модонд дүүлэхдээ чадамгай;* 2. амьтны тэлүүлэн зүтгэлхийлэн агсрах; *нохой уяадаа дүүлэх;* 3. хүний уурсаж дэмий дүрэм үзүүлэн авирлах.

ДҮҮЛЭХ II дүүгээр хэмжих; *будаа дүүлэх.*

ДҮҮЛЭХ III дүүчлэх, дүүгийн ёсноор явах.

ДҮҮЛЭЭЦЭХ амьтны дүүлэн наадах: *хурга ишиг дүүлээцэн тоглож байв.*

ДҮҮПҮҮ буурцгийн гурилыг чанан хандалж түүний хөөсөөр бяслаг мэт шахаж хийсэн

идээний нэр, гол төлөв хоолны хольцод хэрэглэнэ.

ДҮҮРГЭХ дүүрэх I II-ын үйлдүүлэх хэв, дүүрэн болгох, дуусгах, төгсгөх, барагдуулах; *сургууль дүүргэх; ажлаа дүүргэх; гэдсээ дүүргэх; хувинд ус дүүргэх.*

ДҮҮРҮҮЛЭХ дүүрэх I II III-ын үйлдүүлэх хэв.

ДҮҮРЭГ ихээхэн суурин газрын хавь орчны хэсэгхэн хүй.

ДҮҮРЭН 1. саванд юм агуулахад уг савны багтаах хэм хэмжээндээ хүрсэн; *хувин дүүрэн сүү; хөхүүр дүүрэн айраг; авдар дүүрэн бараа; хүүдий дүүрэн будаа; аяга дүүрэн цай;* 2. маш олон, үлэмж; *гудамжинд хүн дүүрэн байна; хот дүүрэн хонь ямаа, тал дүүрэн адуу мал; клуб дүүрэн хүнтэй байна;* 3. ш и л ж с э н элбэг, баян, үлэмж их; *дүүрэн бэлэгтэй; түвшин жаргалтай* е р ө ө л; *уурхай дүүрэн алт, уул дүүрэн мод, ус дүүрэн загас;* 4. ш и л ж с э н хангалттай, ханамжтай; *сэтгэл дүүрэн; ам дүүрэн.*

ДҮҮРЭНДҮҮ нилээд дүүрэн.

ДҮҮРЭХ I 1. саванд юм дүүрэн болох; *хувин дүүрэв;* 2. маш үлэмж, олон болох; *баяр ёслолын үед талбайд хүмүүс дүүрэв.*

ДҮҮРЭХ II 1. дуусах, гүйцэх; *зохиолыг бичиж дүүрэв; юмаа хийж дүүрчээ;* 2. ш и л ж с э н шийдсэн; *ичих зовохыг мэдэхгүй дүүрчихсэн амьтан.*

ДҮҮРЭХ III морь унасан хүн, хүн буюу юмыг эмээл дээрээ багтаан урд талдаа авч явах; *хүүхэд дүүрэх; тэрэг дүүрэх.*

ДҮҮРЭЭ 1. цорой, мах; 2. элгэнд наалдан ургасан нимгэн мах; **элэг дүүрээ х о р ш . .**

ДҮҮЧ ахмад хүнийг дүүгийн ёсоор хүндэтгэгч хүн.

ДҮҮЧЛҮҮЛЭХ дүүчлэхийн үйлдүүлэх хэв.

ДҮҮЧЛЭЛ дүүчлэх үйлийн нэр; *ахчлал дүүчлэл.*

ДҮҮЧЛЭМДЭГ дүүчлэмтгий.

ДҮҮЧЛЭМДЭХ дүүчлэх.

ДҮҮЧЛЭМТГИЙ дүүчлэхдээ сайн.

ДҮҮЧЛЭХ 1. ах хүмүүсийг дүүгийн ёсоор үйлчлэх; 2. өөрийн биеийг бага буюу доод болгож, бусдыг ах зах болгож хүндлэх.

ДЭВ I дэвсэг, дэнж; *дэв газар.*

ДЭВ II: **зэрэг дэв** зэрэг, дэс, дараа: *эрх тушаалын дэв; дэв дэвээрээ суу.*

ДЭВ III бузар, ариун биш, цөв; **бузар дэв** х о р ш . .

ДЭВДРЭХ 1. морь малын ул туурай элж хатуу газар явахад сүйтэлзээ; *миний морь дэвдрээд явж чадахгүй болов;* 2. хүний шүд хөндүүрлэж юм хазахад хүчгүйдэх ба шүд унаж хазахад тохиромжгүй болох; *шүд дэвдрэх;* 3. шувуу далавчаараа газар хавиран нисэх; *алтан хараацай дэвдрэн нисч байв.*

ДЭВДЧИХ 1. байн байн дэвдрэх; 2. үйл ажилд дэм олохгүй ийн тийн тэвдэх; *чи юундаа дэвдэчсэн амьтан бэ?.*

ДЭВЖИХ 1. дэгжих, дээшлэх, өөдлөх; *дэвжиж яваа айл;* 2. өсөх, торних; *дэвжиж байгаа хүүхэд.*

ДЭВЖҮҮЛЭХ дэвжихийн үйлдүүлэх хэв.

ДЭВЖЭЭ 1. ноос савахад дэвссэн юм; *унгасны дэвжээ;* 2. эзэлж байгаа газар; *сурын дэвжээ; шагааны дэвжээ; дэвжээ харвах.*

ДЭВЛЭГ дэвэх дэрвэх үйлийн нэр; *гардийн дэвлэгээр дэвэх; сайхан дэвлэгтэй бөх.*

ДЭВЛЭХ 1. юмны байн байн дэвэх; 2. шингэн юмны аяндаа оргилон халих давлах.

ДЭВЛЭЭ а м ь т а н ус балчиг дэвхээ газар орших хөх дэглийтэй адил болоод маш жижигхэн нэгэн зүйл шувуу.

ДЭВРҮҮ хөөрүү, сагсуу, онгиргон.

ДЭВРҮҮЛЭХ дэврэхийн үйлдүүлэх хэв.

ДЭВРЭХ 1. шингэн буцламгай юмны савнаасаа халих; *тогоотой цай дэврэх;* 2. нэндэх, ихдэх, хэтрэх; *өвчин дэврэх; халуун дэврэх; ааш нь дэврэх;* 3. улам даврах.

ДЭВРЭЭ хөөргөн, онгиргон.

ДЭВРЭЭХ дэврэхийн үйлдүүлэх хэв, дэврэхэд хүргүүлэх.

ДЭВРЭЭЧ хөөрүү, онгиргон зантай.

ДЭВС 1. х у у ч и р с а н эмээлийн олонцог; 2. эдүгээ дөрөөний сурыг даран халхалж унжуулах хэрэгсэл, шир булигаар зэргээр хийнэ.

ДЭВСГЭР 1. дэвсдэг юм: **ширдэг дэвсгэр** х о р ш . ; *гэрийн дэвсгэр; ширмэл дэвсгэр;* 2. газар нутаг; **дэвсгэр нутаг, газар дэвсгэр** х о р ш . ; *Монгол улсын дэвсгэр нутаг; манай нутаг дэвсгэр өргөн уудам;* 3. олон өнгө холимог юмны ар буюу их биений өнгө; *цэнхэр дэвсгэртэй зураг; улаан дэвсгэртэй хоргой;* 4. мөнгөн тэмдэгт цаас; *25-тын дэвсгэр; нэгтийн дэвсгэр;* 5. юмны буурь суурь, бэлтгэл чадал; *тэр гуайнх хэзээний дэвсгэр сайтай айл; тэр ч дэвсгэрээр муухан хүн байх аа;* ☆ **дэвсгэр үсэг** (амьгүй орж болдог гийгүүлэгч үсгүүд).

ДЭВСГЭРГҮЙ буурь суурь, бэлтгэл чадвараар муу дорой; *мэдлэгийн дэвсгэргүй хүн.*

ДЭВСГЭРЛҮҮЛЭХ дэвсгэрлэхийн үйлдүүлэх хэв.

ДЭВСГЭРЛЭХ 1. хүний хөрөнгө чинээ, чадал, мэдлэг нэмэгдэн дэвсгэртэй болох; 2. юмны дор ямар нэгэн зүйлээр дэвсгэр болгох хийх.

ДЭВСГЭРТЭЙ дэвсгэр бүхий, хуучин бэлтгэл бууртай; *дэвсгэртэй айл; дэвсгэр сайтай хүн; дэвсгэртэй зураг.*

ДЭВСЛЭХ дэвсүүх.

ДЭВСМЭЛ дэвссэн юм; *дэвсмэл зам.*

ДЭВСРЭГ дэвсгэр.

ДЭВСҮҮЛЭХ 1. дэвсэхийн үйлдүүлэх хэв; 2. дэвсэгдэх.

ДЭВСҮИХ байн байн дэвсэх.

ДЭВСЭГ орчин газраас өндөрхөн тэгш **дэв газар**; **дэв дэвсэг** х о р ш . .

ДЭВСЭЛХИЙЛЭХ дэвслэх.

ДЭВСЭХ I 1. юмны гадарга дээгүүр дэвсгэр болгож юм тавих; *ширдэг дэвсэх; хивс дэвсэх; буцц дэвсэх; чулуу дэвсэх;* 2. аргадах, царайчлах, гуйх; *хормой дэвсэх; хушуу дэвсэх; хэл дэвсэж ярих.*

ДЭВСЭХ II хөлөө өргөж хүчтэй дэлдэн гишгэх; *няц дэвсэх; чанга дэвсэх хэрэгтэй; газар дэвсэх.*

ДЭВТМЭЛ дэвтсэн юм; *дэвтмэл шир; дэвтмэл үдээр.*

ДЭВТЭГШИХ юмны дэвтэх, норж хөөх, зөөлрөх; *шир дэвтэгших; гутлын ул дэвтэгших.*

ДЭВТЭГШҮҮЛЭХ дэвтэгшихийн үйлдүүлэх хэв.

ДЭВТЭР олноор нь хавсарч товхисон цаас, *ном бичиг; хичээлийн дэвтэр; тэмдэглэлийн дэвтэр; ном дэвтэр; өврийн дэвтэр; гуравдугаар дэвтэр;* **дэвтрийн нүүр** (дэвтрийн эхлэх газар); **дэвтрийн гадар** (дэвтрийн хавтас, гадаад тал); **дэвтрийн товхиос** (дэвтрийн үдээс).

ДЭВТЭРЛҮҮЛЭХ дэвтэрлэхийн үйлдүүлэх хэв.

ДЭВТЭРЛЭГЧ дэвтэр хийдэг хүн.

ДЭВТЭРЛЭХ дэвтэр болгох; *ном дэвтэрлэх; сонин дэвтэрлэх; зураг дэвтэрлэх; цаас дэвтэрлэх.*

ДЭВТЭХ I 1. хатуу юм ус чийгт норж уян зөөлөн болох; *үдээрний шир дэвтжээ; ааруул дэвтэх;* 2. хүний архинд хэтэрхий согтох; *архинд дэвтэх.*

ДЭВТЭХ II дэв болох, бузартах, цөвтөх.

ДЭВТЭЭР архи өнгөний зэрэгт хэтэрч эргүү болсон; *дэвтээр этгээд.*

ДЭВТЭЭХ дэвтэхийн үйлдүүлэх хэв, дэвтэхэд хүргүүлэх.

ДЭВҮҮЛЭХ дэвэхийн үйлдүүлэх хэв.

ДЭВҮҮР I модон хавьсанд цаас бөс торгомсог нааж нугалбарлан хийж, дэвэлхийлэн сэргүцэх хэрэгсэл; *салхины дэвүүр;* **дэвүүрийн унжлага** (дэвүүрт унжуулсан чимэг); **дэвүүрийн хавьс** (дэвүүрийн зурвас зурвас мод); **дэвүүрийн гадар** (дэвүүрийн хавьсанд наасан цаас, бөс); **дэвүүрийн тэнхлэг** (дэвүүрийн хавьсны холбоо).

ДЭВҮҮР II амуу тариа шигших, дэвж цэвэрлэх бургас сийрсээр сүлжиж хийсэн хэрэгсэл; *бургасан дэвүүр; тарианы дэвүүр.*

ДЭВҮҮР III дэхүүр, тоос шорооны гөвүүр.

ДЭВҮҮРДҮҮЛЭХ дэвүүрдэхийн үйлдүүлэх хэв.

ДЭВҮҮРДЭХ дэвүүр, дэвүүрээр дэвэх, гөвөх.

ДЭВХЛЭГЧИН онгоцонд суух буухад дам гишгүүр тавих хүн; *онгоцны дэвхлэгчин.*

ДЭВХЛЭХ 1. морин дээрээс газар буулгүй өөр морин дээр хийлэн унах; *морь дэвхэлж унах;* 2. өндөр юман дээгүүр ухасхийн хийлж давах; *дэвхлэн харайх.*

ДЭВХРҮҮЛЭХ дэвхрэхийн үйлдүүлэх хэв, дэвхрэхэд хүргүүлэх.

ДЭВХРЭГ а м ь т а н шулуун далавчитны салбар язгуурын дэвхэрдэг шавьж, төрөл зүйл олон, ихэд олширвол таримал билчээрт хортой; **дэвхрэг аалз** а м ь т а н (аалзны нам, хорхой шавьжийг дэвхрэн барина, өнгө зүйл бүр, бие бяцхан, зарим зүйл монгол газар бий); **дэвхрэг царцаахай** а м ь т а н (бие шаравтар, жигүүр бяцхан, нисэхгүй нэгэн зүйл царцаахай).

ДЭВХРЭХ хоёр хөлөө зэргээр өргөж цовхрон, хийлэн харайх, харайж дэвхрэх; **дэвхрэх цовхрох** х о р ш.: *өндрөөс дэвхэрч буух; гол дэвхрэн гарах; дэвхэрч явах.*

ДЭВХЦҮҮЛЭХ дэвхцэхийн үйлдүүлэх хэв, дэвхцэхэд хүргүүлэх.

ДЭВХЦЭХ 1. байн байн дэвхрэх; *дэвхцэж тоглох; баярласандаа дэвхцэж байв;* 2. хилэн төрж маш догшрон авирлах; *дэвхцэж дэвхцэж арай зогсов.*

ДЭВХЭЭ угаасаа чийг нойт ихтэй өвс үндэс *няг, зүлэг байдалтай газар; дэвхээ газар;* **дэвхээний чигирмаа цэцэг** у р г а м а л (устай газар ургана, навч шуумгай, иш дүр дөрвөлжин, өнгө цайвар хүрэн улаан, анхилам их үнэртэй нэгэн зүйл цэцэг).

ДЭВШИЛ дэвшсэн нь; *дэвшил сайтай; дэвшил муутай.*

ДЭВШИЛТ I давшилт.

ДЭВШИЛТ II дэвших үйлийн нэр, өөдлөлт, дээшлэлт, ахилт; *дэвшилт хүн төрөлхтөн; дэвшилт үзэлтэн.*

ДЭВШИЛТЭЙ дэвшил бүхий, давшилттай.

ДАВШИСХИЙХ хүн юмны баахан баахан дэвших.

ДЭВШИХ дээшлэх, ахих, өөдлөх; *дээшээ дэвших; тушаал дэвших; суудал зэрэг дэвших;* **нэр дэвших** (нэр цохлон гарах).

ДЭВШЛЭГ дэвшсэн нь, давшилт; *дэвшлэг сайтай; дэвшлэг муутай; дэвшлэгтэй залуу.*

ДЭВШҮҮЛЭХ дэвшихийн үйлдүүлэх хэв, дэвшихэд хүргүүлэх; *өргөн дэвшүүлэх; нэр дэвшүүлэх.*

ДЭВЭГНҮҮЛЭХ дэвэгнэхийн үйлдүүлэх хэв.

ДЭВЭГНЭХ 1. байн байн дэвэх, дэрвэх, дэрвэлзэх, дэвэлзэх; *гэрийн бүрээс салхинд дэвэгнээд байна; өрх дэвэгнэх;* 2. хөнгөн шаламгай хөдлөх; *тэр гуай чинь дэвэгнэсэн сүрхий хүн байна шүү.*

ДЭВЭЛ хүний биед өмсөх хувцасны зүйлийн ерөнхий нэр; хувцас хунар; **дэвэл хувцас** х о р ш..

ДЭВЭЛЗҮҮЛЭХ дэвэлзэхийн үйлдүүлэх хэв, дэвэлзэхэд хүргүүлэх.

ДЭВЭЛЗЭХ байн байн дэвэх, дэрвэх; *салхинд өрх дэвэлзэх; үүд дэвэлзээд байна; дэвэлзсэн хөнгөн хүн.*

ДЭВЭЛХИЙЛЭХ байн байн дэвэх ба дэвлэх.

ДЭВЭР шингэн зүйл агуулах гүц хэлбэртэй *сав; мөнгөн дэвэр; шаазан дэвэр;* 2. хүндэтгэвэл зохих хүний цай агуулах сав; *дэвэртэй зоог.*

ДЭВЭРГЭХ дэврэхэд хүргүүлэх, дэврүүлэх; *цайгаа дэвэргэхэд хүрэв.*

ДЭВЭХ I шувууны жигүүрээ дэлгэж хуугнан хэдлөх; *шувуу дэвэх; бөх дэвэх.*

ДЭВЭХ II амуу тарианы аага хальсыг дэвүүрээр хийсгэн арилгах; *будаа дэвэх.*

ДЭВЭХ III сэрүүцүүлэн сэвэх; *дэвүүрээр дэвэх; бууз дэвэх; дэвж сэвэх.*

ДЭВЭХ IV дэрвэх; **дэвэх дэрвэх** х о р ш.; *дээвэр цаваг дэвж дэрвэх.*

ДЭВЭЭ дэвхээ.

ДЭВЭЭРЭХ олноороо нийлж дарвих, хөгжилдэх; *та нар хэтэрхий дэвээрэх хэрэггүй.*

ДЭГ I горим, журам; *дэгтэй бай!; бүжгийн дэг.*

ДЭГ II: **дэг дуг** хагас хугас; *дэг дуг унтав.*

ДЭГ III: **дэг дуг газар** дээр дор, онхол цонхол; *дэг дуг хийсэн явахад бэрхтэй газар.*

ДЭГГҮЙ журамгүй, горимгүй, дүрсгүй; *дэггүй хүүхэд; дэггүй амьтан.*

ДЭГГҮЙДҮҮ дэггүй байдалтай.

ДЭГГҮЙТЭХ дэггүй зан байдал гаргах.

ДЭГГҮЙХЭН баахан дэггүй.

ДЭГД у р г а м а л навчнаас уламжлан ургадаг хонх мэт цэцэгтэй, цэцгийн өнгө ихэнхдээ хөх, ягаан, намаг, ой модны чөлөөгөөр ургана.

ДЭГДГЭР дэдгэр, явцуу, богино, давч; *дэгдгэр дээл; дэгдгэр хормой; дэгдгэр хүүхэд.*

ДЭГДГЭРХЭН баахан дэгдгэр, арай дэгдгэр.

ДЭГДИЙЛГЭХ дэгдийхийн үйлдүүлэх хэв.

ДЭГДИЙХ дэгдгэр болох, богинодох, дэдийх ч гэнэ.

ДЭГДЛЭХ урт мод тулж дүүлэн харайх.

ДЭГДҮҮР 1. агаарын хувийн жингээс хөнгөн хувийн жин бүхий бөмбөлөг мөн нисэх багаж; 2. агаарт нисгэж наадах цаасаар хийсэн тоглоом, цаасан шувуу ч гэнэ; дэгдүүр нисгэл (наадах цаасан шувуу).

ДЭГДЭГНҮҮЛЭХ дэгдэгнэхийн үйлдүүлэх хэв, дэгдэгнэхэд хүргүүлэх.

ДЭГДЭГНҮҮР хөнгөн, хийсвэр; *дэгдэгнүүр хүн.*

ДЭГДЭГНЭХ 1. тогтворгүй маш хөнгөн долгин байдалтай байх ба тийм ааш авир гаргах; *дэгдэгнэсэн сүрхий хөнгөн шингэн хүн;* 2. дэгдгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ДЭГДЭЛЗЭХ 1. дэгдэгнэх, дэдэгнэх; 2. дэгдгэр юмны байн байн хөдлөх.

ДЭГДЭНЭ бүднээ шувууны зулзага.

ДЭГДЭХ 1. юмны газраас хөндийрөн ойж эргэн газарт хүрч дахин ойж үсрэх; *хүүхэд дэгдэх; туулай дэгдэх; шувуу дэгдэх; хөх тэнгэрт хөвөн, хөрст алтан дэлхийд дэгдэж яв* (аман зохиол); 2. шилжсэн ямар нэг үзэгдэл, үйл явдлын гэнэт үүсэх; *хуй дэгдэх; салхи дэгдэх; өвчин дэгдэх; цуурхал дэгдэх; яриа дэгдэх; дайн дэгдэх; шуугиан дэгдэх; үймээн дэгдэх; хэрэг дэгдэх.*

ДЭГДЭЭХ дэгдэхийн үйлдүүлэх хэв, дэгдэхэд хүргүүлэх; *хэрэг дэгдээхэд хялбар.*

ДЭГДЭЭХИЙ шувууны жигүүр нь ургаж *яваа зулзага; галууны дэгдээхэй; тахианы дэгдээхий.*

ДЭГЖДЭХ хэтэрхий дэгжин болох.

ДЭГЖИЛ дэгжих үйлийн нэр; дэвшил, дэвжил, өөдлөл.

ДЭГЖИН ганган, хээнцэр, гөёмсог; *дэгжин хүүхэн.*

ДЭГЖИНДҮҮ дэгжин байдалтай.

ДЭГЖИНДЭХ хэтэрхий дэгждэх.

ДЭГЖИРХҮҮЛЭХ дэгжирхэхийн үйлдүүлэх хэв.

ДЭГЖИРХЭХ дэгжин байдал гаргах.

ДЭГЖИХ 1. дээшлэх, дэгдэх; *шувуу нисэн дэгжих;* 2. дэвжих, үржих; *амьдрал нь дэгжиж яваа айл;* 3. хөгжих, бадрах; *гал дэгжих.*

ДЭГЖРЭХ 1. дэгжин болох; 2. дэвжих, дэгжих, дээшлэх.

ДЭГЖҮҮЛЭХ дэгжихийн үйлдүүлэх хэв, дэгжихэд хүргүүлэх.

ДЭГЖЭЭХ дэгжихэд хүргүүлэх, дэгжүүлэх.

ДЭГЛИЙ I 1. үстэй охор хүрэм; *нэхий дэглий;* 2. мөрөвч хормогчгүй хуяг; *дэглий хуяг.*

ДЭГЛИЙ II хайч өрөлбө зэргийн хавсран хадсан хадаас; *хайчны дэглий.*

ДЭГЛИЙ III амьтан толгойдоо өвөгтэй, өндөр хүзүүтэй, урт хушуутай нэгэн зүйл шувуу; цагаан, хөх, элгэн өнгөтэй, их бага хэд хэдэн зүйл бий.

ДЭГЛҮҮ (Н) хэвлүүн, их зантай, маягтай; *дэглүүн хүүхэд.*

ДЭГЛҮҮДЭХ хэтэрхий дэглүүн болох.

ДЭГЛҮҮЛЭХ дэглэх I-ийн үйлдүүлэх хэв.

ДЭГЛҮҮРХЭХ дэглүүн зан байдал гаргах.

ДЭГЛҮҮЛЭХ дэглэх I-ийн үйлдүүлэх хэв.

ДЭГЛЭГДЭХ II төөрөх, будлих, тээглэгдэх.

ДЭГЛЭМ журам, зарчим, хэв заншил; *дэглэм зөрчих; дэглэм дагах; ажлын дэглэм.*

ДЭГЛЭМШИХ дэглэмтэй болох, журамших.

ДЭГЛЭХ I юмыг дэглэм горимоор нь дууриан авч хэрэглэх; *бүжиг дэглэх; цам дэглэх; кино дэглэх.*

ДЭГЛЭХ II хэвлүүн, дэглүүн зан байдал гаргах.

ДЭГМЭЛ: дэгмэл хонгор гайхал хонгор шувууны өөр нэр.

ДЭГНИЙЛГЭХ дэгнийхийн үйлдүүлэх хэв, дэгнэгэр болгох.

ДЭГНИЙХ дэгнэгэр болох.

ДЭГНҮҮЛ дов сондуул; *дэгнүүлтэй газраар явахад төвөгтэй.*

ДЭГНЭГНЭХ дэгнэгэр юмны үргэлжлэн хөдлөх, данхганах.

ДЭГНЭГЭР данхар, дэнхгэр, дэнхэр; *дэгнэгэр толгойтой.*

ДЭГНЭЛЗҮҮР бамбалзуур, намалзуур.

ДЭГНЭЛЗЭХ 1. дэнхэлзэх, дэнхгэнэх; 2. намалзах, бамбалзах.

ДЭГС 1. харвах буудах шидэх зэрэгт оновол зохих тусгал чигээс гажсан алдаа; **дэгс буудах** (буудахад оновол зохих зүйлээ онохгүй алдах); 2. мөчид, хуумгай; *дэгс хүний үгийг итгэж болохгүй;* **дэгс ярих** (худал хэлэх).

ДЭГСДҮҮ худалч, болгоомжгүй

ДЭГСДҮҮЛЭХ дэгсдэхийн үйлдүүлэх хэв, дэгс болгох.

ДЭГСДЭХ дэгс болох, болгох; *буу дэгсдэх; дэгсдэж ярих.*

ДЭГСЛҮҮЛЭХ дэгслэхийн үйлдүүлэх хэв, дэгслэхэд хүргүүлэх.

ДЭГСЛЭХ дэгс болгох, дэгсдүүлэх.

ДЭГЦЭХ дэгэх, догонцох; *чөдөртэй морь дэгцэж яваа харагдана; хүүхэд дэгцэж наадав.*

ДЭГЭН: дэгэн догон тэгш биш, тогтворгүй хөдөлгөөнтэйн байдал; *ширээ дэгэн догон хийх; дэгэн догон хийсэн эвгүй газар.*

ДЭГЭНЦЭХ дэгцэх, догонцох, дэгэн догон хийх.

ДЭГЭЭ 1. юмыг өлгөж гогодох хэрэгсэл; *загасны дэгээ; дэгээ төмөр; мах өлгөх дэгээ; хон хон дуутай, хондлой дээрээ дэгээтэй* о н ь с г о; 2. бөхийн мэх; **дэгээ хийх, дотуур дэгээ хийх** (эсэргүүцэл бөхийн хөлийн дотуур талаар хөлөөрөө хөлийг нь гохдох); **гадуур дэгээ** (эсэргүүцэл бөхийн хөлийн гадуур талаас хөлөөрөө хөлий нь гохдох); 3. заль, мэх, бач, бааш; *дэгээтэй хүн; араа дэгээ нь хэтрээд ярьж болдоггүй амьтан.*

ДЭГЭЭДҮҮЛЭХ дэгээдэхийн үйлдүүлэх хэв.

ДЭГЭЭДЭХ 1. юмыг дэгээгээр гохдох, үгтээх; 2. егөөдөх, ёжлох; 3. барилдах бөхчүүдийн дэгээлэх мэх хийх.

ДЭГЭЭЛЭХ 1. дэгээдэх; 2. хүний үйл явдалд бач бааш гаргах; 3. юмны иш онгинд хөндлөн нүх гаргаж бэхлэн хадах тогтоох.

ДЭД хоёрдугаар, хэргэм, цол зэрэг, тушаалаар хоёрдугаар дахь; *дэд дэвтэр; дэд зэрэг; дэд сайд; дэд жанжин; дэд эрдэмтэн; дэд хурандаа.*

ДЭДГЭР хувцасны явцуу жижиг, арьс шир зэргийн бага татгар; *дэдгэр бага дээл; дэдгэр жижиг арьс нэхий.*

ДЭДИЙЛГЭХ дэдийхийн үйлдүүлэх хэв.

ДЭДИЙХ дэдгэр болох, дэгдийх ч гэнэ.

ДЭДЛЭХ дэдэд болох, орох,

ДЭДЭГНҮҮР түвтүүргүй зантай хүн.

ДЭДЭГНЭХ 1. хүн амьтны түвтүүргүй авир ааш гаргах; *дэдэгнэсэн сүрхий хүн байна;* 2. *дэдгэр юмны үргэлжлэн хөдлөх.*

ДЭДЭЛЗЭХ дэдгэр юмны байн байн хөдлөх.

ДЭЛ I 1. адуу луус илжиг зэргийн амьтны хүзүү сэрвээний тус ургасан урт хялгас; *морины дэл; азраганы дэл;* **хур дэл** (унаганаас нь хяргаагүй ургуулсан дэл; *хур дэлтэй хээр азрага);* 2. ш и л ж с э н юмны дээгүүр нарийн зурваслаж товойлгон тавьсан янзлал; *дэл тавих; дэлтэй гаансны толгой; цүүцний дэл.*

ДЭЛ II **дэл сул** 1. ил задгай; *юм хум нь дэл сул хэвтэж байв;* 2. үрэмхий, юмаа хайргүй эдэлдэг; *дэл сул хүн.*

ДЭЛ III у р г а м а л дулаан оронд ургадаг нэг зүйл ургамлын үр, маш тослог, хар цагаан хоёр зүйл бий, гүнжид ч гэдэг; *дэлийн тос.*

ДЭЛБИЙЛГЭХ дэлбийхийн үйлдүүлэх хэв.

ДЭЛБИЙХ дэлбэгэр болох; *дэлбийсэн чихтэй.*

ДЭЛБЭ I 1. цэцгийн дан буюу наалдсан хэлтсээр бүтсэн хэсэг; *цэцгийн дэлбэ;* 2. чихний хавтгай хэсэг; *чихний дэлбэ.*

ДЭЛБЭ II хүч нэмэгдүүлэх үг; *дэлбэ чихих; дэлбэ үсрэх;* **дэлбэ дайрах** (а. юмны байгаа савааа хага татах: б. хаагдсан боогдсон юм хаалт боолтоо задлах; в. бөөн юманд бутран багтартал орох); **дэлбэ татах** (юмыг зориуд дэлбэлэх).

ДЭЛБЭГ I элбэг; **элбэг дэлбэг** х о р ш.; *эд агуурсаар элбэг дэлбэг.*

ДЭЛБЭГ II тэрэгний морины жолоо.

ДЭЛБЭГ III дэлбэгэр; **дэлбэг аяга** (сартгар амсартай шаазан аяга).

ДЭЛБЭГЛЭХ тэрэг, онгоц, завь зэргийг мориор чиргүүлэх; *онгоц дэлбэглэх.*

ДЭЛБЭГНҮҮЛЭХ дэлбэгнэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЛБЭГНЭХ дэлбэгэр юмны дэлбэг дэлбэг хөдлөх.

ДЭЛБЭГЧ тэрэг жолоодож явуулах хүн.

ДЭЛБЭГЭР дэрэвгэр, том, далбагар; *дэлбэгэр чихтэй хүн; дэлбэгэр малгай; дэлбэгэр цэцэг; дэлбэгэр амсартай.*

ДЭЛБЭГЭРДЭХ хэтэрхий дэлбэгэр байх.

ДЭЛБЭЛЗҮҮЛЭХ дэлбэлзэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЛБЭЛЗЭХ дэлбэгэр юмны дэлбэс дэлбэс хөдлөх.

ДЭЛБЭЛҮҮЛЭХ дэлбэлэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЛБЭЛЭГЧ дэлбэлдэг мэрэгжилтэй тэслэгч.

ДЭЛБЭЛЭХ дэлбэрэхийн үйлдүүлэх хэв, дэлбэрэхэд хүргүүлэх; *мөс дэлбэлэх; чулуу дэлбэлэх;* ☆ **дэлбэлэх гийгүүлэгч** (уушигнаас гарсан хийг хэл, уруул зэрэг өгүүлэх эрхтэн хааж байгаад гэнэт нээхэд гарсан авиа).

ДЭЛБЭН дэлбэгэр; *дэлбэн аяга; дэлбэн чих.*

ДЭЛБЭРҮҮЛЭХ дэлбэрэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЛБЭРХИЙ дэлбэрсэн юм.

ДЭЛБЭРЭЛ дэлбэрэх үйлийн нэр, юманд гарсан цав гав.

ДЭЛБЭРЭЛТ тэсрэлт; *атомын дэлбэрэлт; галт уулын дэлбэрэлт.*

ДЭЛБЭРЭХ 1. тэсрэх, доторхи хүчинд хагарах; *дэлбэрэн хөлдөх; бөмбөг дэлбэрэх; галт уул дэлбэрэх;* 2. шилжсэн хэвийн хэмжээнээс хэтрэхэд хүрэх; *уур нь дэлбэрэхэд хүрэв; дэлбэртэл идэх; дэлбэртэл баяжих.*

ДЭЛБЭХ I тэрэг жолоодох.

ДЭЛБЭХ II элбэх; **элбэх дэлбэх хорш.**

ДЭЛБЭЭ дэлбэ.

ДЭЛБЭЭЛЭХ цэцгийн дэлгэрэн гаргах; *цэцэг дэлбээлэх.*

ДЭЛГҮҮ уужим, тавиу; *дэлгүү амтай сав; дэлгүү зайтай газар.*

ДЭЛГҮҮДЭХ хэтэрхий дэлгүү болох.

ДЭЛГҮҮЛЭХ 1. дэлгэхийн үйлдүүлэх хэв, дэлгэхэд хүргүүлэх; 2. дэлгэгдэх.

ДЭЛГҮҮР юм худалдаалах газар; *бөс барааны дэлгүүр; идэш уушны дэлгүүр; дэлгүүрт очих.*

ДЭЛГЭР 1. юм бүхэн хангалттай, элбэг дэлбэг: **зуны дэлгэр цаг** (хамаг бодис дэлгэрсэн цаг,*жаргалтай дэлгэр зуныхаа сард, жигүүртэн олон олон шувуу та минь* (уртын дуу); 2. бүтэн, дүүрэн; **дэлгэр саран** (тэргэл, дүүрэн сар); 3. олон, газар сайгүй үзэгдэх: *дэлгэр болсон заншил;* 4 .баялаг, өргөн уудам; *дэлгэр монгол орноо, магтаж бид нар дуулахдаа.*

ДЭЛГЭРҮҮЛЭХ дэлгэрэхийн үйлдүүлэх хэв, дэлгэрэхэд хүргүүлэх; *тэргүүний туршлага дэлгэрүүлэх.*

ДЭЛГЭРЭНГҮЙ 1. товч, бага, хураангуй биш; *дэлгэрэнгүй илтгэл; дэлгэрэнгүй ярих; дэлгэрэнгүй бичих;* 2. дэлгэр, элбэг, олон; *энэ бол дэлгэрэнгүй үзэгддэг явдал.*

ДЭЛГЭРЭХ 1. тараах, түгээх, элбэг болох, дэлгэр болох; *цагаан идээ дэлгэрэх; өвчин дэлгэрэх;* 2. өрнөх, бадрах, мандах; *цэцэг дэлгэрэх; хувьсгал дэлгэрэх.*

ДЭЛГЭХ 1. тэнийлгэх, толийлгох, сарвайлгах; *хуйлаастай зургийг дэлгэв; далавчаа дэлгэв; атгаастай гараа дэлгэх;* 2. тараах; *ширээн дээгүүр элдэв юм дэлгэн тавьжээ;* 3. ихэд нээх, онгойлгох; *ном дэлгэж суув; үүд дэлгэж орхих;* 4. үлэмж ярих, хүүрнэх; *яриа дэлгэх; үг дэлгэх.*

ДЭЛГЭЦ юм дэлгэх, тарааж тавих, тусгахад зориуясан хэрэгсэл; *аарууллын дэлгэц; киноны дэлгэц; манай дэлгэц дээр.*

ДЭЛДГЭР хэвийн хэмжээнээс дэлбэгэр, унжсан, сартайсан; *дэлдгэр чих; чих нь дэлдгэр малгай.*

ДЭЛДГЭРДҮҮ дэлдгэр байдалтай.

ДЭЛДГЭРХЭН баахан дэлдгэр, арай дэлдгэр.

ДЭЛДИЙЛГЭХ дэлдийхийн үйлдүүлэх хэв, дэлдгэр болгох.

ДЭЛДИЙХ дэлдгэр болох; *чих нь дэлдийв.*

ДЭЛДҮҮ ургамал далдуу модны нэг: зүйл.

ДЭЛДҮҮЛЭХ I 1. дэлдэх I-ийн үйлдүүлэх хэв,; 2. дэлдэгдэх.

ДЭЛДҮҮЛЭХ II дэлдэх II-ын үйлдүүлэх хэв, дэлээс нь бариулах, чангаалгах .

ДЭЛДЭГНҮҮЛЭХ дэлдэгнэхийн үйлдүүлэх хэв; *чихээ дэлдэгнүүлэх.*

ДЭЛДЭГНЭХ 1. хүний зуйгуурлан ялгам ааш авир гаргах, долдгонох ч гэнэ; 2. дэлдгэр юмны дэлдэг дэлдэг хөдлөх.

ДЭЛДЭЛЗҮҮЛЭХ дэлдэлзэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЛДЭЛЗЭХ дэлдгэр юмны дэлдэс дэлдэс хөдлөх.

ДЭЛДЭН зарим юмны хэвийн хэмжээнээс дэлбэгэр том; *дэлдэн чих; туулай шиг дэлдэн чихтэй.*

ДЭЛДЭХ I цохих, дэлсэх, жанчих; *хэнгэрэг дэлдэх; төмөр дэлдэх; модоор дэлдэх.*

ДЭЛДЭХ II адуу малын дэлээс барих, үгтээх; *наад морио дэлдэж байгаад хазаарла!.*

ДЭЛЛҮҮЛЭХ дэллэхийн үйлдүүлэх хэв, дэллэхэд хүргүүлэх.

ДЭЛЛЭХ дэлийг хяргаж авах, засах; *адуу дэллэх.*

ДЭЛСГЭХ дэлсэхэд хүргүүлэх, дэлсгүүлэх.

ДЭЛСГЭЭ унаж эдэлж зүдэрсэн морь малын навины тус ойлхилон цохилох өвчин.

ДЭЛСҮҮЛЭХ дэлсэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЛСЭХ I дэлдэх, цохих; *зүрх дэлсэх; модоор дэлсэх.*

ДЭЛСЭХ II морь малд дэлсгээ өвчин тохиолдох.

ДЭЛСЭЭ дэлсгээ.

ДЭЛСЭЭХ дэлсгэх.

ДЭЛТ дэл бүхий юм; *дэлтэй цоож; дэлтэй морь;* **дэлт чоно** а м ь т а н (сүүгээр бойжигч, зантгар том толгойтой, бүдүүн хүзүүтэй, хүчирхэг шүдтэй, урд хөл майга, богинохон сүүлтэй, сэрвээ нуруу дагуу дэл бүхий нэг зүйл чоно); **дэлт мод** у р г а м а л (хоёр тал нь хумигардуу бөгөөд дэллэсэн бүдүүн гол бүхий навчтай, хавар цэцэглэдэг нэгэн зүйл навчит мод).

ДЭЛҮҮ I 1. амьтны бие махбодийн дотор, цусны бөөмийг гаргаж, үүнтэй холбогдох элдэв нарийн үйлийг бүтээх эрхтэн; *дэлүүг хатгах;* 2. амьтны дэлүү үрэвсэж өвчлөх өвчин; *дэлүү тусах.*

ДЭЛҮҮ II илүү; **илүү дэлүү** х о р ш..

ДЭЛҮҮРҮҮЛЭХ дэлүүрэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЛҮҮРХЭХ мэгжийн, ховс гахай хүсэн эрэх; *дэлүүрсэн мэгж.*

ДЭЛҮҮРЭХ 1. мал, сүргээс салж дэмий тэнэн зогсох; 2. ш и л ж с э н дэмий чалчин ярих; 3. амьтны дэлүү өвчин хүрэх, дэлүүтэх.

ДЭЛҮҮТҮҮЛЭХ дэлүүтэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЛҮҮТЭХ мал гөрөөсөнд дэлүү өвчин тусах; *үхэр дэлүүтэх.*

ДЭЛХИЙ өөрийн тэнхлэгийг даган эргэж нарыг тойрох, нарнаас гадагших гуравдугаар гариг буюу ертөнц; **манай дэлхий** (газрын бөмбөрцөг): *алтан дэлхий;* **дэлхий дахин** (бүх дэлхий); **дэлхийн бөмбөрцөг** (газрын бөмбөрцөг); **дэлхийн байдал** (газар зүй); **дэлхийн царцдас** (газрын өнгөн талын хатуу давхрага, гүн нь 15—70 километр).

ДЭЛЭВЧ амьтны хөх дэлэнг дарах халхлах хэрэгсэл; *ямааны дэлэвч.*

ДЭЛЭВЧЛЭХ амьтны дэлэнд дэлэвч зүүх; *цагаан ямаагаа дэлэвчил!.*

ДЭЛЭГНЭХ төрөх ойртож дэлэн нь томрох; *үнээ дэлэгнэж байна.*

ДЭЛЭГЧ а м ь т а н хатуу бүрхүүл далавчит нэг зүйл нисдэг шавьж.

ДЭЛЭМ нэг гарыг сунгаж, нөгөө гарыг нугалан хурууны үзүүрийг тэр талын мөр орчинд хүргэсэн хэмжээ; алдын хагас наяад см.; *алд дэлэм.*

ДЭЛЭМЛЭХ дэлмээр хэмжих.

ДЭЛЭН (Г) I 1. хөхөөр тэжээх амьтны эмэгчний сүү гаргах, товч бүхий эрхтэн; **хөх дэлэн** х о р ш.; *үнээний дэлэн;* 2 .малын дэлэн цочиж үрэвсэх өвчин; *хар дэлэн.*

ДЭЛЭН II модны ур, бундуу.

ДЭЛЭНДЭХ 1. дэлэнгээс барих; 2 .ш и л ж с э н хүнийг царайчлан гуйлхилан дагах; *сайн дэлэндсэний хүчээр хэргээ бүтээв.*

ДЭЛЭНТЭХ малд дэлэн сочих өвчин тохиолдох.

ДЭЛЭНЧ а м ь т а н хос далавчитны салбар маш жижиг ялаа, хүн малд халдамтгай.

ДЭЛЭХ 1. дэвэх юмыг тэнийлгэн дээш доош савлах; *шувуу далавчаа дэлэв; бөх дэлж дэвэх;* 2. дүүрэн татах; *нум дэлэх;* 3. түгэх, тарах, их болох; *өвчин дэлэх; яр шарх дэлэх; ус дэлэх.*

ДЭМ 1. ая эв, арга зүй; *дэмийг олох; дэм өгөх; дэмтэй хүн;* 2. үйл явдалд бусдаас олсон ямар нэгэн тусламж дэмжлэгийн зүйл; *дэм авах; дэм дэмжлэг үзүүлэх; дэм дэмдээ, дээс эрчиндээ* х у у ч.

ДЭМГҮЙ 1. ая эв, арга зүйгүй; 2. тус дэмжлэггүй.

ДЭМЖИГДЭХ дэмжихийн үйлдэгдэх хэв.

ДЭМЖИХ тэтгэх, туслах, дэм үзүүлэх; **дэмжих туслах** х о р ш.; *санал дэмжих; би тэр асуудлыг дэмжинэ.*

ДЭМЖЛЭГ дэмжих үйлийн нэр; тусламж, туслалцаа, тулгуур; *дэмжлэг үзүүлэх; тэр ч цаанаа нилээд дэмжлэгтэй хүн байгаа юм.*

ДЭМЖҮҮЛЭХ 1. дэмжихийн үйлдүүлэх хэв; 2. дэмжигдэх.

ДЭМИЙ 1. зүйг дагахгүй, дур зоргоор; *дэмий амьтан;* 2. хэрэггүй, үр ашиггүй; **дэмий балай** х о р ш.; *дэмий юм; дэмий тэнэх; дэмий үг ярих; шал дэмий; дэмий юманд явж ажлаа үрэх хэрэг юун!.*

ДЭМИЙЛ дэмий.

ДЭМИЙРҮҮЛЭХ дэмийрэхийн үйлдүүлэх хэв, дэмийрэхэд хүргүүлэх.

ДЭМИЙРЭХ 1. дэмий болох, хэрэг зориггүй хоосоор тэнэх; *дэмийрэн явах;* 2. ухаан элий балай болох, дэмий ярьж солиорох; *дэмийрэх өвчин.*

ДЭМНҮҮР 1. дүүжин оосор; *дэмнүүр олс;* 2. дэмжлэг, дэм; *дэмнүүр сайтай хүн.*

ДЭМНЭХ I дэмжих, туслах, дэмжлэг болох.

ДЭМНЭХ II дүүжигнэх, дэмнүүрээр наадах; *дэмнэж наадах.*

ДЭМТЭЙ 1. арга тай, зүйтэй, дэм бүхий; *гартаа дэмтэй;* 2. дэмжлэг сайтай, түшигтэй; *хамт ажиллахад дэмтэй сайн нөхөр.*

ДЭМЧ 1. х у у ч и р с а н хутагтын шавь нарт шанзавын дараахь албан тушаал; *тамгын дэмч;* **2. х у у ч и р с а н** сумын зарлага; *сумын дэмч; дэмч шүүлэнгэ;* 3. хурлын сүмийн харгалзагч; *сумийн дэмч.*

ДЭН (Г) I хөвөнгөөр гол хийж тос цутган ноцоож гэрлийг хэрэглэх зүйл; *дэнгийн гэрэл; дэн барих;* **цахилгаан дэн** (чийдэн).

ДЭН II дян; *дэн буудал.*

ДЭН III **дэн дун** 1. арай муруй, арай ядан; *дэн дун дээсэн дөрөөтэй явна;* 2. элий балай, ухаан саруулгүй; *миний ухаан дэн дун байв.*

ДЭНДГЭНЭХ дэндгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ДЭНДГЭР дэнжгэр, хөл суурь өндөр юм; *дэндгэр аалз; дэндгэр хөлтэй ширээ.*

ДЭНДГЭРДЭХ хэтэрхий дэндгэр болох.

ДЭНДИЙЛГЭХ дэндийхийн үйлдүүлэх хэв, дэндгэр болгох; *өрхөө дэндийлгээрэй.*

ДЭНДИЙХ дэндгэр болох, дөндийх; *өрх дэндийх.*

ДЭНДҮҮ хэтэрхий, хэтрүү; *дэндүү муухай зантай; дэндүү удаан бичих; дэндүү назгай амьтан.*

ДЭНДҮҮЛЭХ дэндэхийн үйлдүүлэх хэв, хэтрүүлэх.

ДЭНДЭЛЗЭХ дэндгэр юмны байн байн дэндэс дэндэс хөдлөх.

ДЭНДЭХ хэтрэх, хэтэрхийдэх, дэндүү болох; *байшин доторхи халуун арай дэндэж байна; их уувал дэндэнэ.*

ДЭНЖ нам дор газраас арай өндөрлөг мөгүү мөрөгцөгтэй тэгшдүү дэв газар; *уулын бэлийн дэнж; голын дэнж; өндөр дэнж дээр өргөөгөө барьж өргөн ширэг дээр зэлээ татаж...* е р ө в л.

ДЭНЖГЭР дээд этгээд дэндгэр дэндгэрдүү, доод этгээд шувтан буюу өндөр нарийн зүүзгэр юм; *дэнжгэр ширээ; дэнжгэр шат; дэнжгэр аалз.*

ДЭНЖГЭРДЭХ хэтэрхий дэнжгэр болох.

ДЭНЖИГНҮҮЛЭХ дэнжигнэхийн үйлдүүлэх хэв.

ДЭНЖИГНЭХ дэнжгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ДЭНЖИЙЛГЭХ дэнжийхийн үйлдүүлэх хэв, дэнжгэр болгох.

ДЭНЖИЙХ дэнжгэр болох; *хадан дээр дэнжийн зогсож байв.*

ДЭНЖИЛЗҮҮЛЭХ дэнжилзэхийн үйлдүүлэх хэв.

ДЭНЖИЛЗЭХ дэнжгэр юмны байн байн хөдлөх.

ДЭНЛҮҮ бүрхүүлт зул, лаа; *шөнийн гүнээ дэнлүү барин явж байв; Шивээ Хиагтыг авахад шилэн дэнлүү хэрэггүй...* (ардын дуу).

ДЭНС алт мөнгө зэргийг хэмжих хэмжүүр; **дэнсний таваг** (хэмжих юмыг тавих сав): **дэнсний нуруу** (дэнсний тэнгийн мод); **дэнсний од** (дэнсний нурууны хэмжүүрийн цэг); **дэнсний утас** (нуруу модны өргөх оосор); **дэнсний туухай** (дэнсний тэнцүүр годил).

ДЭНСЛҮҮЛЭХ 1. дэнслэхийн үйлдүүлэх хэв; 2. дэнслэгдэх.

ДЭНСЛЭГ 1. доргио, донсолгоо; *тэрэгний дэнслэг;* 2. сэтгэл догдлох, гуниглах, уйтгарлах нь.

ДЭНСЛЭГДЭХ 1. дэнслэх II-ын үйлдэгдэх хэв, доргигдох, донслогдох; 2. сэтгэл дэнслэх, тогтворгүй үймчих; *сэтгэл дэнслэгдэх.*

ДЭНСЛЭХ I дэнсээр хэмжих; *алт дэнслэх; эм дэнслэх.*

ДЭНСЛЭХ II 1. донслох; **дэнслэх донслох** х о р ш.; 2. амгалангүй болох, гуниглах ,догдлох; *дэнсэлсэн хоёр сэтгэлийг дэмий битгий зовоогоорой* (уртын дуу).

ДЭНСЛЭХ III удаан хугацаагаар өлсөж зовуурлах; *дэнслэн зовох.*

ДЭНСЭЛГЭХ дэнслэх II-ын үйлдүүлэх хэв, амруулахгүй элдэвчлэн зовоох; *дэнсэлгэн зовоох.*

ДЭНСЭЛГЭЭ донсолгоо, доргио.

ДЭНТЭЙ: дэнтэй **дунтай** .арай чарай, дөнгеж дангаж, эдий буудай; *дэнтэй дунтай гарав; дэнтэй дунтай байсан тэд.*

ДЭНХГЭР данхгар, дээгүүрээ том; *дэнхгэр толгойтой.*

ДЭНХИЙЛГЭХ дэнхийхийн үйлдүүлэх хэв, дэнхгэр болгох.

ДЭНХИЙХ дэнхгэр болох; *дэнхийсэн эвэртэй шар.*

ДЭНХМЭЛ зан байдал муу хэрцгий бөгөөд тэнэмэл, тэнэмхий; *дэнхмэл хүн.*

ДЭНХЭГНҮҮЛЭХ дэнхэгнэхийн үйлдүүлэх хэв.

ДЭНХЭГНЭХ дэнхгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ДЭНХЭЛЗҮҮЛЭХ дэнхэлзэхийн үйлдүүлэх хэв.

ДЭНХЭЛЗЭХ дэнхгэр юмны байн байн хөдлөх.

ДЭНХЭР данхар, дэнхгэр; *дэнхэр толгой; дэнхэр эвэртэй.*

ДЭНЧИН барьцаа болгож тавьсан юм; *дээлийн торгоор дэнчин тавина хөө* (ардын дуу).

ДЭНЧИНДЭХ дэнчин тавих, дэнчин болгох.

ДЭНШИХ доргих, донслох.

ДЭНШЭЭ доргио, донсолгоо; *дэншээ ихтэй газар.*

ДЭНЭЛЗҮҮР бамбалзуур; дэнэлзүүр газар.

ДЭНЭЛЗЭХ бамбалзах. намалзах.

ДЭР 1. толгойн түшүүр, жинтүү; *өдөн дэр; дэрний гэр; дэрний уут; дэрний бүтээлэг;* **ор дэр** х о р ш.: **дэр нэгдэх** (эр эм болөлцож нэгэн дэр дэвсгэрт хамтдах); 2. юмны доогуур тавьсан ивүүр; *босгоны дэр; дэр чулуу; төмөр замын дэр мод.*

ДЭРВИЙЛГЭХ дэрвийхийн үйлдүүлэх хэв, дэрэвгэр болгох.

ДЭРВИЙХ дэрэвгэр болох; **эрвийх дэрвийхээрээ** (бүхий л аргаараа, бүхий л бололцоогоороо); *бүгдээрээ эрвийх дэрвийхээрээ хүчлээрэй.*

ДЭРВЭГНҮҮЛЭХ дэрвэгнэхийн үйлдүүлэх хэв.

ДЭРВЭГНЭХ дэрэвгэр юмны үргэлжлэн хөдлөх; *туг далбаа дэрвэгнэх; майхан салхинд дэрвэгнэх.*

ДЭРВЭГЭЛЗЭХ шувууны зулзага зэргийн жижиг амьтны далавч жигүүрээ дэвэлхийлэн хөдөлгөх.

ДЭРВЭГЭР 1. юмны ам амсар цалгай дэлгүү; *дэрвэгэр амсартай аяга; дэрвэгэр амтай ваар;* 2 .эрвэгэр; **эрэвгэр дэрэвгэр** х о р ш.; 3. дэргэр, далбагар; *дэрвэгэр малгай.*

ДЭРВЭЛЗҮҮЛЭХ дэрвэлзэхийн үйлдүүлэх хэв.

ДЭРВЭЛЗЭХ дэрэвгэр юмны байн байн хөдлөх.

ДЭРВЭЛХИЙЛЭХ байн байн дэрвэх.

ДЭРВЭХ юмны дэвэгнэх, дэрвэлзэх; *хүүхэд дэгж дэрвэх; шувуу далавчаа дэрвэх; дээвэр цаваг салхинд дэрвэх.*

ДЭРГЭД хажууд, маш ойр, шадар, байхад; *миний дэргэд ирж суув; дэргэдээс нь харахад түн өндөр уул; Засгийн газрын ордны дэргэд; хүний дэргэд ингэж хэлэв; аавын дэргэд бай-*

гаа хүн хэн гэдэг билээ?; **дэргэд бараа болох** (дэргэд нь байх); **дэргэдийхэн** (шадар байгчид, дэргэд нь байгчид).

ДЭРГЭДЭХ дэргэд байх, хажууд байгаа; *дэргэдэх хүндээ хэл; алтны дэргэдэх гууль шарлана* з ү й р; *Сангийн яамны дэргэдэх* олон нийтийн байгууллага.

ДЭРГЭР даргар, дэрэвгэр байдалтай юм; *дэргэр чихтэй хүн; дэргэр эвэртэй үхэр.*

ДЭРДГЭР дардгар, дэржгэр; *дэрдгэр адсага.*

ДЭРДИЙЛГЭХ дэрдийхийн үйлдүүлэх хэв, дэрдгэр болгох.

ДЭРДИЙХ дэрдгэр болох; *арьсны год дэрдийж харагдав.*

ДЭРДЭГНЭХ 1. дэрдгэр юмны дэрдэг дэрдэг хийх, дэрвэн хөдлөх, доргин хөдлөх; 2. ш и л ж с э н хөнгөн долгин ааш гаргах; *дэрдгэнэн гүйх.*

ДЭРДЭЛЗЭХ дэрдгэр юмны дэрдэс дэрдэс хөдлөх.

ДЭРЖГЭР дэрдгэр.

ДЭРЖИГНҮҮЛЭХ дэржигнэхийн үйлдүүлэх хэв.

ДЭРЖИГНҮҮР доргиж донсолгох байдалтай болсон юм; *дэржигнүүртэй зам.*

ДЭРЖИГНЭХ 1. дэржгэр юмны дэржиг дэржиг хөдлөх; 2. чичирхийлэх, доргих.

ДЭРИЙЛГЭХ дэрийхийн үйлдүүлэх хэв, дэргэр болгох.

ДЭРИЙХ дэргэр болох, дарайх, дэрдийх; *дэрийтэл хатсан арьс.*

ДЭРЛҮҮЛЭХ дэрлэхийн үйлдүүлэх хэв, дэртэй болгох.

ДЭРЛЭХ 1. дэр дээр толгойгоо тавих, түших; *дэр дэрлэх* 2. юмны нэг этгээд юманд түшиж налах; *уул дэрлэж буух; ус дэрлэж нутаглах;* 3. дараа дараагаар ирэх, очих; *хойно хойноосоо дэрлэх; бөгс бөгсөө дэрлэх.*

ДЭРМИЙЛГЭХ дэрмийхийн үйлдүүлэх хэв, дэрэмгэр болгох.

ДЭРМИЙХ дэрэмгэр болох; *чих нь дэрмийгээд нүд нь зэрмийсэн.*

ДЭРМЭГНЭХ дэрэмгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ДЭРМЭЛЗЭХ дэрэмгэр юмны байн байн хөдлөх.

ДЭРС у р г а м а л сайр нуга, хээр талд ургадаг хатуу нарийн иштэй, үет дагаантай адил нэг зүйл өвс; нялх ногоонд нь мал идэг, ишээр нь сүлжиж юм хийнэ: **дэрсэн малгай** (дэрсээр хийсэн бүрх малгай).

ДЭРСДЭХ дэрс ихтэйн учир тохиромжгүй болох.

ДЭРСРЭХ дэрс шиг болох, дэрсэрхүү болох.

ДЭРЧГЭР дэлдэн, дэрмийсэн; *дэрчгэр чихт.*

ДЭРЧИГНҮҮЛЭХ дэрчигнэхийн үйлдүүлэх хэв.

ДЭРЧИГНЭХ дэрчгэр юмны дэрчиг дэрчиг хөдлөх.

ДЭРЧИЙЛГЭХ дэрчийхийн үйлдүүлэх хэв, дэрчгэр болгох.

ДЭРЧИЙХ дэрчгэр болох; *дэрчийсэн чихтэй хүүхэд.*

ДЭРЧИЛЗҮҮЛЭХ дэрчилзэхийн үйлдүүлэх хэв.

ДЭРЧИЛЗЭХ дэрчгэр юмны дэрчис дэрчис хөдлөх.

ДЭРЭВГЭЛЗЭХ 1. шувууны зулзага үүртээ зогсож далавчаа дэрвэлхийлэх; 2. дэрэвгэр юмны баахан баахан дэрвэлзэх.

ДЭРЭВГЭР дэрвэгэр.

ДЭРЭМГЭЛЗЭХ дэрэмгэнэх, зэрэмгэнэх, дэрмэлзэх.

ДЭРЭМГЭР 1. дэрдгэр; *дэрэмгэр чихтэй;* 2. зэрэмгэр; *дэрэмгэр нүдтэй охин.*

ДЭРЭНХИЙ 1. юмыг сананандаа тунгаахгүй, хийсвэрлэн явдаг; *дэрэнхий зантай;* 2. захирах хүний зөвшөөрөлгүй дур зоргоор явдаг, танхай; *дэрэнхий этгээд.*

ДЭРЭНХИЙЛЭХ дэрэнхий зан гаргах.

ДЭРЭНХИЙТЭХ дэрэнхий танхай байдал гаргах.

ДЭС 1. зэрэг, дараа; **дэс дугаар** (зэрэг дугаар); **дэс дэсээр** (удаа дараагаар); **дэс дараа** (юмыг нэг нэгээр дараалсан нь; *дэс дараагий нь олох);* **дэс дараалах** (дэс дараатай болгох); 2. х у у ч и р с а н дэд, хоёрдугаар; *дэс түшмэл.*

ДЭСЛЭГЧ арми ба хөлөг онгоцны офицерын цол, зэрэг; **бага дэслэгч** (офицерын анхны цол); **ахлах дэслэгч** (мөн гуравдугаар [illegible]).

ДЭСЛЭХ 1. дэсэд болох, дэд нь болох, хоёрдугаар нь болох; **дэслэх түшмэл** (дэс түшмэл); 2. дэс дараалах.

ДЭХҮҮР шувууны өдөөр хийсэн шороо тоос гүвэх арилгах зүйл; *тоосны дэхүүр; өдөн дэхүүр.*

ДЭХҮҮРДЭХ дэхүүрээр дэвэлхийлэх, дэвүүрдэх.

ДЭЦ өнгө цагаан, чанар маш хөнгөн нэгэн зүйл төмөрлөг; сав суулга хийнэ, хөнгөн цагаан ч гэдэг.

ДЭЦДЭХ дэцээр өнгөлөх, гагнах.

ДЭЭВЭР юмны дээд этгээд, түүнийг өнгөлж бүрхсэн юм; *гэрийн дээвэр; байшингийн дээвэр; төмөр дээвэр; модон дээвэр; ваар дээвэр.*

ДЭЭВЭРЛҮҮЛЭХ дээвэрлэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЭВЭРЛЭХ дээвэр хийх, дээвэртэй болгох; *төмрөөр дээвэрлэх; модоор дээвэрлэх.*

ДЭЭГ барсыг хатгах жаданд хүлээслэсэн хөндлөн мод.

ДЭЭГҮҮР 1. дээд этгээд, өндөрт; *дээгүүр нисэх; дээгүүр өнгийх;* 2. дээд зэрэгт; *дээгүүр тушаалтай; дээгүүр зантай; дээгүүр санаа;* 3. өнгөн талаар; *мөсөн дээгүүр гулгах; зүлэг дээгүүр явах;* ☆ **дээгүүр дэрэнхий** (зан авир хөнгөн хуумгай).

ДЭЭГҮҮРДҮҮЛЭХ дээгүүрдэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЭГҮҮРДЭХ хэтэрхий дээгүүр болох.

ДЭЭГҮҮРЛЭХ дээгүүр зан байдал гаргах.

ДЭЭГҮҮРТҮҮЛЭХ дээгүүртэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЭГҮҮРТЭХ улмаар дээгүүр болох.

ДЭЭГҮҮРХ дээр, дээгүүр байгаа; *сүүн дээгүүрх өрөм; ширээ дээгүүрх юм; үүл дээгүүрх үүл; газар дээгүүрх ургамал.*

ДЭЭГҮҮРХЭН баахан дээгүүр, арай дээгүүр.

ДЭЭД доод гэдгийн эсрэг утга 1. огторгуйн зүг тийш, юмны толгой буюу цээж этгээд; *дээд тэнгэр; дээд бие; модны дээд үзүүр; цонхны дээд тал; дээд зовхи;* 2. юмны эх буюу ах зах тал; *усны дээд тал; манай дээд хотын хүмүүс; салхины дээд талаас; дээд талд нь суух;* 3. чанараар эрхэм сайн; *дээд зэргийн цаг; алтны дээд нь шижир, агтны дээд нь аргамаг, эрдмийн дээд бичиг, эдийн дээд хадаг; нөхрийн дээд;* 4. өмнөх, өнгөрсөн үе; *монголын дээд өвөг; манай дээд үе; дээд үеэс үлдсэн өв соёл;* 5. эрх үүрэг, зэрэг дэвээр дээгүүр; *дээд эзэн; дээд эрх барих газар; дээд байгууллага; улсын дээд шүүх таслах газар; дээд тушаал; дээд доодын ялгавар;* 6. боловсролын зэргээр өндөр их; *дээд сургууль; дээд боловсрол; дээд мэрэгжилтэй;* 7. юмны дээр нь байгаа, нүүр буюу өнгөнд нь байгаа; *дээд давхрын айл; дээд талын номыг аваад аль; дээд өнгөн будаг нь ховхорчээ;* 8. хэмжээ бүхий юмны эцэс туйл; *дээд зах нь тавин төгрөг хэрэгтэй; дээд захын баян айл түмэн малтай байв; дээд зах нь уншдаг бичдэг; доод зах нь үсэг таньдаг* болов; 9. тэргүүн, нэгдүгээр, урьдахь; *дээд дэвтэр; дээд морь; дээд боть; дээд хуудас;* **дээдийн хагас** (шинийн наймны заримдаг сар): **дээд монгол** (Хөх нуурын монголчууд).

ДЭЭДЛҮҮЛЭХ дээдлэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЭДЛЭХ дээд болгон үзэх; *дээдлэн хүндэтгэх.*

ДЭЭДЭС 1. дээд үеийн; **өвөг дээдэс** х о р ш.; *дээдсийн өв соёл;* 2. дээд зэрэгтэн; *дээдсийн зарлиг; сургааль;* 3. ш а ш и н тэнгэрийн орныхон; **тэнгэр дээдэс** х о р ш..

ДЭЭДЭХ дээр бий, дээд **талд** бүхий; *манай дээдэх айл; шүүгээний дээдэх нүдийг татаад үз!; цонхны дээдэх янз мод.*

ДЭЭДЭЧЛЭХ дээдэд үзэж нэн хүндэтгэх; *дээдэчлэн үзэх;*

ДЭЭЖ 1. ямар нэгэн юмнаас тусгай зорилгоор охь хувь болгон авсан юм; *цайны дээж; архины дээж; хоолны дээж; алтны дээж; нүүрсний дээж; ургамлын дээж; чулууны дээж; дээр нь сууж дээжий нь идэх;* **дээж барих** (олсон хийсэн эд идээнээс эрхэмлэх хүнд өгөх); **дээж амсах** (идээ ундааны зүйлд түрүүлж ам хүрэх); **дээжий нь авах** (юмны охь хувийг урьдчилан авах); **дээж өргөх** (идээ ундааны зүйлийн түрүүчээс авч газар дэлхийд зориулан сацах); 2. х у у ч и р с а н юмны дотроос онц тасархай илүү сайхан; **хүний дээж** (хүний дээд); **дээж морь** (дээд зэргийн морь).

ДЭЭЖЛҮҮЛЭХ дээжлэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЭЖЛЭХ дээжийг авах, амсах, үлдээх.

ДЭЭЛ гадуур өмсөх энгэр зах бүхий урт хувцас; *зуны дээл; өвлийн дээл; дээл хийх;* **дээл мялаах** (эцэг эх нь үр хүүхдээ шинэ дээл өмсөхөд нь билэгтэй үг хэлж, урамшуулах); **дээлийн өнгө** (а. дээлийн гадар тал; б. дээлийн гадар хийх эд бөс); **дээлийн юм** (а. дээлийн өнгө хийх эд: б. дээл хийхэд хэрэглэгдэх зүйл); **дээлийн гадар** (дээлийн өнгө); **дээлийн оноо** (суганы дагуу, ташааны доод, хормойн тушаа битүүлэн оёогүй үлдээсэн газар); **дээлийн тавтир** (дээлийн хормойн илүүхэн унжуу болсон газар); **дээлийн ташаа** (дээлийн хормойг өргөтгөхийн тул голлосон бүсний хоёр хажууд оруулсан гурвалжин хушуу оруулга); **дээлийн хайдаг** (зувцаа дээлийн хажлага); **дээлийн шат** хуучирсан (эхнэр хүний дээлд гэдэсний тушаа өөр зүйлийн эдээр үйлдэж хөндлөн хадсан дөрвөлжин зүйл).

ДЭЭР дор гэдгийн эсрэг утга; 1. дээд зүгт, дээд талд, гадарга талд; *дээр тэнгэр хол; дээр дээр нь тавих; модон дээр сандайлах; зүлгэн дээр хэвтэх; өвдөг дээрээс буудах; газар дээр ганц; дээл дээр тос дусах; номын хавтсан дээр; мөсөн дээр; цасан дээр гарсан мөр;* 2. түрүүн, эрт, урьд, хуучин, өмнө; *чамайг гадаадад сургуульд явах гэж байна гэдгий чинь дээр мэдсэн; дээр дурдсан зүйлээс үзэхэд...; эрт дээр үед; дээр үеийн хүмүүсийн эдлэл хэрэглэл;* 3. гадна, тусгай; *үндсэн цалингийн дээр; энэ морин дээр юм нэмж өгье; үүний дээр юу авах вэ?;* 4. чанараар дор биш, илүү давуу, сайн; *модны бүдүүн, махны тарган дээр; чиний мориноос миний морь дээр; энэ хоёрын алин дээр вэ?; үүнээс тэр нь дээр; чадлаар дээр; сурлагаар дээр; дээр давхисан морь;* 5. дээш, өөд, өндөрт, дээр гарах; *дээр газар сэрүүн; уулан дээр гарах; байшингийн орой дээр туг босгох;* 6. даруйд нь, тэр дор нь; *би санасан дээрээ хэлье; юм халуун дээрээ дээр байдаг; бороо сэгхийсэн дээр явцгаая; төмрийг халуун дээр нь давтах хэрэгтэй; ямааны мах халуун дээрээ;* 7. нэрийн дор; *аавын нэр дээр байгаа машин; миний нэр дээр данстай мал; над дээр захидал чинь ирсэн, аваарай;* 8. улам ахих; *авсан дээрээ авах; хийсэн дээрээ дуусах; залуу дээрээ залуу болох; унтсан дээрээ унтах; сурсан дээрээ сур!; гэрэл дээрээ гэрэлтэй болох;* 9. орныг заах утга; *аймаг дээр очих; сумын дээр хүрэх; хөдөө аж ахуй дээр ажиллах; дарга дээрээ орох; захирал дээр орох; Доржийн дээр хүлээж бай, би чам дээр маргааш очно;* 10. бусад үгтэй нийлж янз бүрийн утга санааг илэрхийлнэ; **дав дээр** (урьдаар, юуны өмнө; *энэ ажлыг дав дээр хийж үз; дав дээр үүнийг авч бай!);* **толгой дээр гарах** (а. эрх хэмжээнээс хэтэрч улам даврах; б. уулын толгой дээр гарах); **дээр гарах** (а. өндөр өөд гарах; *нар дээр гарах;* б. дээгүүр, ахих, давших; *нас дээр гарах; эрх тушаалаар дээр гарах);* **дээр нь гарах** (а. дээд талд гарах; *дээр нь суух;* б. дийлэх, давах; *үг хэлээр дээр нь гарах; эр чадлаар дээр нь гарах);* **хэрэг дээрээ** (чанартаа, *үнэн хэрэг дээрээ*).

ДЭЭРДҮҮЛЭХ дээрдэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЭРДЭХ хэтэрхий дээр болох; *газар нь дээрдээд таарахгүй байна; бие нь дээрдэж байна.*

ДЭЭРСГҮҮЛЭХ дээрсгэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЭРСГЭХ улам дээр болгох.

ДЭЭРСЭХ улам дээр болох.

ДЭЭРТГҮҮЛЭХ дээртгэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЭРТГЭХ улам дээр болгох, сайжруулах; *миний аргыг дээртгээд өгсөн байна.*

ДЭЭРТҮҮЛЭХ дээртэхийн үйлдүүлэх хэв, улмаар дээр болгох.

ДЭЭРТЭХ улам дээр болбох, сайжрах, дээш болох, засрах.

ДЭЭРЭЛХҮҮ бусдад дээрэлхэх зан байдалтай, дээрэнгүй; *дээрэлхүү зангаа татаарай.*

ДЭЭРЭЛХҮҮЛЭХ 1. дээрэлхэхийн үйлдүүлэх хэв; 2. дээрэлхэгдэх.

ДЭЭРЭЛХЭГ дээрэлхүү, дээрэнгүй

ДЭЭРЭЛХЭХ 1. бусдыг дээрэнгүйлэн дарлах, доромжлох, биеэ дээрд үзэх; 2. хүний биед өндөрлөг газар тохиромжгүй болох; *газар дээрэлхэх.*

ДЭЭРЭМ илт булаах, илэрхий хулгай, бүлэглэсэн хулгай; **хулгай дээрэм** хор ш.: **дээрмийн дайн** (түрэмгийлэн эзлэх дайн).

ДЭЭРЭМДҮҮЛЭХ 1. дээрэмдэхийн үйлдүүлэх хэв; 2. дээрэмдэгдэх.

ДЭЭРЭМДЭХ илэрхийгээр хүчдэн уулгалан булааж авах, дээрэм хийх.

ДЭЭРЭМЛЭХ дээрэм хийх, уулгалан булаах.

ДЭЭРЭМЧ дээрэм хийдэг хүн.

ДЭЭРЭМЧИН дээрэмч.

ДЭЭРЭНГҮЙ доромжлох зантай, дээрэлхэг, дарлангуй.

ДЭЭРЭНГҮЙЛҮҮЛЭХ 1. дээрэнгүйлэхийн үйлдүүлэх хэв; 2. дээрэнгүйлэгдэх.

ДЭЭРЭНГҮЙЛЭХ дээрэнгүй зан байдал гаргах, доромжлон сүрдүүлэх.

ДЭЭРЭЭС 1. дээр гэдэг үгний гарахын тийн ялгалын хэлбэр; *дээрээс өнгийж харах; нисэх онгоц дээрээс баяр хүргэв;* 2. учир, учраас; *би орон гэргүй дээрээс ажил хийж чадахгүй байна; шүм дээрээс; тийм дээрээс.*

ДЭЭС үс хялгас, олс хийм зэргээр томж хийсэн оосор; **олс дээс, сур дээс** х о р ш.; **дээс томох** (ноос үсийг самчин түүдэг хийж баруун солгой эрч оруулан нийтгэх); **дээс татах** (а. гаднын хүн оруулахгүйн тулд хөл хорьсон тэмдэг болгож гэр ба хаалганы тус газар дээс уяж сунган тавих; б. дээслэх); **дээс харайлах** (а. багачуудын тоглоом, хоёр хүн, дээсний хоёр үзүүрийг барьж сажин, нэг хүн харайлан наадах; б. өөрөө дээсний хоёр үзүүрээс барьж сажин, өөрөө харайлж наадах); **дээсэн дөрөөтэй гарах** (ямар нэг бэрхшээлийг дөнгөн данган давах).

ДЭЭСЛЭХ юмыг дээсээр сунган хэмжих; *газар дээслэх.*

ДЭЭСРЭХ дээс болох, эрчлэгдэн мушгирах.

ДЭЭШ доош гэдгийн эсрэг утга; 1. юмны эх ба өндөр хийгээд дээд өөд тийш; *дээш босох; дээш өргөх; дээш нь явуулах; дээш авирах; дээш дэвших;* **дээш татах** (а. хүн амьтны ядуу доройг туслах тэтгэх зэргээр дээшлүүлэн дэмжих; б. унасан тарсан уруудсан юмыг эмхлүүлэн өөд татах); 2. цааш, илүү, доошгүй; *зуугаас дээш төгрөг; арваас дээш адуу.*

ДЭЭШДҮҮЛЭХ дээшлэхийн үйлдүүлэх хэв.

ДЭЭШДЭХ хэтэрхий дээш болох; *заасан хэмжээнээс дээшдэвэл тохирохгүй болно шүү!*

ДЭЭШЛҮҮЛЭХ дээшлэхийн үйлдүүлэх хэв, дээш болгох.

ДЭЭШЛЭХ доошлох гэдгийн эсрэг утга; 1. юмны өөдлөх, сайжрах, дэгжих, дээш болох; *манайх дээшилж буух санаатай; дээшилж яваа айл олон;* 2. босохын хүндэтгэл.

ДЮЙМ урт богинын хэмжүүр, фунтийг 12 хуваасны нэг буюу 25,4 миллиметр.

ДЯН аян явдлын хүний буух суухад зориулан бэлтгэсэн буудлын газар, буурч гэр ч гэдэг; **дян буудал** х о р ш.

Е

Е монголын цагаан толгойн үсэг; хоёр авиаг тэмдэглэнэ; эгшиг гийгүүлэгч хавсарсан үсэг, эгшиг гийгүүлэгч хавсарсан авиа.

ЕГӨГДӨХ 1. егөхийн үйлдэгдэх хэв; 2. дийлдэх, автагдах, доройтох; *хүйтэнд бие егөгдөх; зудад мал егөгдөх.*

ЕГӨӨ 1. битүү далд утгаар ёжлон хэлэх үг; *егөөтэй үг;* 2. хашир дорь; *егөөтэй хүн.*

ЕГӨӨДӨХ буздыг битүү үгээр шууд биш ёжлон хэлэх; *та дандаа егөөдөж байдгаа болы!.*

ЕГӨӨДҮҮЛЭХ 1. егөөдөхийн үйлдүүлэх хэв; 2. егөөдөгдөх.

ЕГӨӨЛӨХ егөөдөх, егөө гаргах; *тэр дандаа егөөлж байдаг юм.*

ЕГӨХ 1. ёжлох, егөөдөх; *үгээр егөх;* 2. буздыг битүүгээр дийлэх, хорсгох; *ажлаараа егөх.*

ЕГҮҮЛЭХ 1. егөхийн үйлдүүлэх хэв, егөхөд хүргүүлэх; 2. егөгдөх, дийлдэх; *битүүгээр егүүлэв бололтой.*

ЕМБҮҮ тусгай хэвд цутгасан мөнгө, ихэвчлэн тавин лан хэмжээтэй байдаг, өлгий мөнгөтэй гэнэ.

ЕНХГӨР туранхайвтар янхигар биетэй, царайны үзэмж муутайхан байдалтай; *енхгөр өвгөн.*

ЕНХИЙХ енхгөр хүний байгаа байдал; *енхийсөн сурхий эр.*

ЕНХӨГНӨХ енхгөр хүний енхөг енхөг хөдлөх.

ЕНХӨЛЗӨХ енхгөр хүний енхөс енхөс хөдлөх.

ЕНХӨЛЗҮҮЛЭХ енхөлзөхийн үйлдүүлэх хэв.

ЕНХӨР енхгөр.

ЕР I 1. сул, зүгээр; *ер явна; ер суна; ер*

хэснэ; 2. огт; *ер үзээгүй; ер сонсоогүй; ер мэдэхгүй;* 3. хэрэв; *ер тийм бол хэрхэх билээ!, ер ингээд үзвэл яадаг бол, үзье;* 4. энгийн жирийн; *ерийн хэрэг; ерийн эд; ерийн хүн;* 5. нийтийн, олны; *ерийн байдал; ерийн үзэгдэл; ерийн жишээ; ер бусын явдал;* 6. угаас, дандаа; *ер энэ хэрэг тийм байх ёстой; ер нь хэний ч мэдээж хэрэг байсан; ерөөс болдоггүй хүн; ер тэгж явдаг зантай юм.*

ЕР (ЭН) II тооны нэр, ная дээр нэгийг нэмсэн нь; *есөн арав ер; ерэн хонь; ерэн хоног.*

ЕРГӨӨ морины шогших хатирах хоёрын дунд ширүүвтэрхэн явах явдал; *ергөө сайтай морь; ергөөгөөр явах.*

ЕРГӨХ ергөө явдлаар явах; *ергөж явбал ядрагаа багатай бөгөөд газар хороохдоо сайн байдаг; ширүүхэн ергөхгүй бол газар хорохгүй нь.*

ЕРГҮҮЛЭХ ергөхийн үйлдүүлэх хэв, үргэлжлэн ергөж явах.

ЕРД ер; *ердийн юм; ердийн зан; ердийн үзэгдэл;* **ердийн хөсөг** (зүтгэх хүчинд хэрэглэгдэх мал адгуус); **ердийн тээвэр** (ердийн хөсгөөр тээх тээвэр).

ЕРДӨӨ 1. угтаа, ер нь; *ердөө болдоггүй хэрэг;* 2. энгийндээ; *ердөө сул сууж болохгүй;* 3. бий, бүхий; *би ердөө арван хоньтой; миний ном ердөө гурав.*

ЕРДҮГЭЭР дэс дараалсан тооны ерд тохиолдсон нь; *ердүгээр зүйл; ердүгээр суудал.*

ЕРӨНДӨГ үйл хэргийн бадралыг номготгон чадагч зонхилох юм; *өвчний ерөндөг эм; мунхгийн ерөндөг эрдэм.*

ЕРӨНХИЙ 1. нийгэм, нийт, нэгдсэн, хамтатгасан байдал; *ерөнхий дүн; ерөнхий санаа; ерөнхий анги;* **ерөнхий боловсрол** (байгаль, нийгмийн үзэгдэл хийгээд мэрэгжил эзэмшихэд чухал хэрэгцээ бүхий шинжлэх ухааны ерөнхий үндсийг заан сургах хэмжээ); **ерөнхий боловсролын сургууль** (сурагчдыг ерөнхий боловсролд сургах сургууль); 2. төвлөн удирдах газар буюу албан тушаал; *ерөнхий газар; ерөнхий хороо; ерөнхий сайд; ерөнхий инженер; ерөнхий хэлтэс; ерөнхий нябо;* 3. гол төлөв; бүдүүн тойм, барагцаа, багцаа; *ерөнхий байдал нь ийм байна; ерөнхий санаа нь адил юм; ерөнхий тоймы нь авч үзвэл... .*

ЕРӨНХИЙДӨӨ нийтдээ, үндсэндээ, дүндээ; *ерөнхийдөө санал нь нэгдсэн байна; ерөнхийдөө зүгээр сайн болжээ.*

ЕРӨНХИЙДӨХ хэтэрхий ерөнхий болох *ерөнхийдөөл бүрхэгдэнэ.*

ЕРӨНХИЙЛӨГЧ 1. улсын дээд эрхийг барих газрыг ерөнхийлөн удирдагчийн албан тушаал; 2. эрдэм шинжилгээний томоохон байгууллагыг ерөнхийлөн удирдагчийн албан тушаал; *Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгч; дэд ерөнхийлөгч.*

ЕРӨНХИЙЛӨХ 1. ерөнхий болгох; *ерөнхийлбөл хийсвэр болох нь зайлшгүй;* 2. товчлох, голгойлох; *ерөнхийлөн хянах; ерөнхийлөн удирдах; ерөнхийлөн захирах.*

ЕРӨӨЛ ерөөх үйлийн нэр; 1. ардын аман зохиолын нэг төрөл, сайн сайхныг хүсэж мөрөөдсөн зохиол; *эсгийн ерөөл; сархдын ерөөл;* 2. юмны магтаал бэлэгдэл үг; **ерөөл тавих** (а. аливаа үйл явдалд сайн сайхныг хүсэж ерөөх; б. баяр наадам, пайр хуримд бэлэгтэй үгсийг хэлэх); **ерөөл айлтгах** хуучирсан (нас нөгцөгсдийг сайн төрөл олох болтугай гэж барьц барьж ном айлтгах).

ЕРӨӨЛГӨХ 1. ерөөхийн үйлдүүлэх хэв; 2. ерөөгдөх.

ЕРӨӨЛТ ерөөл, хувь, учрал бүхий; *ерөөлт үгс.*

ЕРӨӨЛЧ ерөөл хэлдэг хүн; *ардын ерөөлч.*

ЕРӨӨР ерөөл.

ЕРӨӨХ бэлэг зохиож, сайн сайхан үг өгүүлэх хэлэх.

ЕРТӨНЦ 1. бидний байгаа газар дэлхийг оршиж байгаа юмны хамт нийтэд нь; *манай энэ ертөнц;* 2. одон гараг оггоргуйн хязгааргүй дахь олон орчлонгуудын зарим хэсэг; *нарны аймгийн ертөнцөс;* 3. ямар нэгэн үзэгдэл ба хүн адгуус, амьтан ургамлыг нийтэд нь; *хүний ертөнц; адгуусан амьтны ертөнц; ургамлын ертөнц;* 4. шилжсэн хүний нийгэмлэгт онцлог шинжээрээ нэгдсэн томоохон хэсэг; *нийгэм журамт ертөнц; хөрөнгөт ертөнц;* **шим ертөнц** (газрын бөмбөрцөг дээрх бүх амьд бодис); **сав ертөнц** (газар дэлхий болон бүх амьгүй бодис).

ЕРҮҮЛ ерэн тоотой юм хамт; *бид ерүүл санал нэгдсэн; ерүүл гарын үсэг зурсан.*

ЕРХӨГ ургамал говь хангайн бүсэнд ургадаг олон наст урт өвс; шулуун босоо иштэй, түрүү нь самны шүд мэт, малын тэжээлд хэрэглэдэг сайн чанарын ургамал.

ЕРЭНТЭЭ ерэн удаа.

ЕРЭЭД 1. ер орчим, ер шахам; 2. тус бүр ер.

ЕС (ӨН) 1. тооны нэр, гурван гурвын нийлбэр; *есөн ес наян нэг; есөн тэмээ; есөн давхар;* 2. сарны зурхайн ёсны хорин дөрвөн улирлын нэг, өвлийн туйл, нар буцах өдрөөс эхлэн хойшлох наян нэгэн хоног; **нялх гурван ес** (эхний гурван ес); **идэр гурван ес** (дундахь гурван ес); **хөгшин гурван ес** (эцсийн гурван ес); 3. хуучирсан гэмт хэрэг үйлдэгчдэд ял унагааж есөн мал торгож авах шийтгэл; *(ес торгох; есөөр торгогдох);* **ес эхлэх** (сарны зурхайн ёсны өвлийн туйл болж нар буцах, нарны зурхайн арван хоёрдугаар сарын хорин хоёрын орчим эхлэнэ); **ес барих; ес өргөх, ес хүргэх** хуучирсан (ихэс дээдэс хүнд хүндэтгэн баярын ёсоор бэлэглэхэд бурхан, хадаг, элэгсгийн хох нэжгээд, цагаан морь найм, булган молцогтой цагаан тэмээ нэг, элдэв идээ жимсний хамт өгөх); **ес авах, ес торгох** (торгож есөн мал албадан авах).

ЕСДҮГЭЭР дэс дараалсан тооны есөд тохиолдсон нь; *есдүгээр сар; есдүгээр суудал.*

ЕСЛӨХ хуучирсан урьдын цагт гэмт хэрэг үйлдэгсдэд ял унагааж малын зүйл дутмаас есөөд мал торгож албадан авах.

ЕСӨГЧИН үлгэрийн амьтан; есөн толгойтой, есөн сүүлтэй, барсын хумстай, хүүхэд шиг дуутай гөрөөс.

ЕСӨН 1. ес; 2. ес дээр тохиолдсон өдөр; *нэгдүгээр сарын есөн; гуравдугаар сарын арван есөн;* **есөн эрдэнэ** (алт, мөнгө, шүр, сувд, оюу, номин, лавай, зэс, болд энэ ес); **есөн гараг** (Адьяа, Сумьяа, Ангараг, Буд, Бархасвадь, Сугар, Санчир, Раах, Жидүү энэ ес); **есөн гархи** (төмөрлөг цагаригт хэлхсэн есөн гархийг тайлах зүүх зэргээр наадах тоглоом); **есөн төрөлхтөн** (хамаг төрөлхтөн амьтан); **есөн цагаан** хуучирсан (ихэс дээдэст хүндэтгэн баярын ёсоор бэлэглэх найман цагаан морь, нэг цагаан тэмээ); **есөн урсгал** хуучирсан (бичгийн зүйл, бумбын зүйл, билэг аргын зүйл, цаазны зүйл, нэрийн зүйл, эрхүүдийн зүйл, хөндлөн гулдын зүйл, бага сагын зүйл, тариаланчийн зүйл энэ ес); **есөн мөргөл** хуучирсан (гурван үе сөгдөж, сөгдөл дутамд гурвантаа мэхэсхийн мөргөх мөргөл); **есөн орон** (а. есөн сүв; б. шашин сэтгэлийн дүрсгүй есөн орон гэж байдаг); **есөн мэнгэ** шашин (зурхайн ёсны үзлэгийн зүйл); **есөн нүх** (гол төлөв есөн настай хүүхдэд энхрийлэн зүүлгэх есөн нүхтэй төмөр).

ЕСӨНТЭЭ есөн удаа, ес дахин.

ЕСӨӨД 1. тус тус ес; 2. ес орчим.

ЕСТ: ест боорцог шүлхийн гурилаар бүрхээр боорцгийн адил хийж гадуур нь зүйл бүрийн жимс тавьж жигнэн хийсэн нэгэн зүйл идээ; **ест жүрж** ургамал (бэрсүүт жүржийн нам, дотроо есөн хэлтэстэй нэгэн зүйл жимс).

ЕСҮҮЛ есөн тоотой юм хамт; *бид есүүл ирэв; есүүл байна.*

ЕЭ харамсах, үл тоомсорлоход гаргах аялга; *еэ тоогүй!; еэ, чи хүрээд ирэв үү.*

ЕЭВЭН гурилаар хийсэн нарийн боов; *цагаан еэвэн; бор еэвэн.*

ЕЭЖГЭР еэзгэр; *еэжгэр эруутэй; еэжгэр шүдтэй.*

ЕЭЖИЙХ еэзгэр болох.

ЕЭЗГЭР еэжгэр.

ЕЭТГЭР матиган маягийн хэлбэр; *еэтгэр ултай гутал.*

ЕЭТГЭРДЭХ хэтэрхий еэтгэр болох.

ЕЭТГЭРХЭН баахан еэтгэр.

ЕЭТИЙХ еэтгэр болох; *еэтийсэн хамартай.*

Ё

Ё монголын цагаан толгойн үсэг, эгшиг гийгүүлэгч хавсарсан үсэг.

ЁВРОГОТОЙ 1. муухай ааш зантай; *ёвроготой дуугарах; ёвроготой загнах;* 2. егөөтэй *ёвроготой үгтэй хүн шүү.*

ЁВРОХ бусдыг гараар буюу өөр зүйлээр нудран түлхэх; *тохойгоороо ёврох.*

ЁВРОХИЛОХ бусдыг баахан зандархийлэх; *ёврохийлсан хачин зантай хүн.*

ЁВРУУЛАХ 1. ёврохын үйлдүүлэх хэв; 2. ёврогдох; 3. бусдад битүүгээр егөгдөх.

ЁВУУР ёврох зэвсэг: *ёвуур мод.*

ЁВЧИХ 1. байн байн ёврох; *гараар ёвчих;* 2. ёвчуур зан гаргах; *ёвчсон зантай хүн.*

ЁВЧОО эв дүйгүй, муухай ааштай; *ёвчоо хүн.*

ЁВЧУУЛАХ 1. ёвчихын үйлдүүлэх хэв; 2. ёвчигдох.

ЁВЧУУР ёвчоо; *тэр гуайн ёвчуур нь хэтрээд байна.*

ЁГТ илэрхий биш утгатай; *ёгт үг; ёгт нэр; ёгтоор хэлэх;* **ёгт үлгэр** (далд утга бүхий сургамжийн бяцхан өгүүлэл буюу шүлэг; *ёгт үлгэр зохиоч*).

ЁГТЛОЛ ёгтолсон юм, утга далдалсан юм.

ЁГТЛОХ утгыг баахан далдлан хэлэлцэх; **ёжлох ёгтлох** х о р ш.

ЁГТЛУУЛАХ ёгтлохын үйлдүүлэх хэв.

ЁДОР 1. хүний хүүр оршуулах газарт хатгах мод; *ёдор босгох;* 2. хээрийн ганц мод; *талын ганц ёдор.*

ЁЖ 1. егөө; 2 .арга мэх, башир заль; *ёжтой хүн; ёжтой үг.*

ЁЖГҮЙ элдэв мэх залигүй, түвшин томоотой; *ёжгүй хүн.*

ЁЖИРХОХ ёжтой үг хэлэх, битүүгээр егөх.

ЁЖИРХУУ ёжломтгой.

ЁЖЛОМТГОЙ ёжлох зантай.

ЁЖЛОХ 1. элдэв далд утгатай үгээр бусдыг егөөдөн хэлэх; *намайг ёжлох санаатай байна;* 2. башир бач гаргах.

ЁЖЛУУЛАХ 1. ёжлохын үйлдүүлэх хэв; 2. ёжлогдох; *ёжлуулж ёжлуулж ирэв.*

ЁЖТОЙ 1. ямагт ёжлох зантай; *ёжтой харах; ёжтой үг хэлэх;* 2. хуурамч зантай, бач бааштай.

ЁЖТОХ ёжтой зан байдал гаргах.

ЁЖТУУЛАХ ёжтохын үйлдүүлэх хэв.

ЁЗООР уг, үндэс, бөгс; *модны ёзоор; уургын ёзоор; ёзоортой үг;* **үзүүр ёзооргүй** (эх захгүй).

ЁЙЛОХ ёолох; *ёйлох дуун гарав.*

ЁЛ а м ь т а н тасаас том, толгой цагаан, бие үнсэн өнгөтэй, гэдэс шаравтар, өндөр уул хаданд оршдог нэгэн зүйл махчин шувуу; **ёл нохой** (хушуу, сүүл бүдүүн, уруул унжуу, чих том нохой.

ЁЛБОГОР зөөлөн буурай, сул улбагар; *ёлбогор биетэй хүн; ёлбогор эд.*

ЁЛБОЙЛГОХ ёлбойхын үйлдүүлэх хэв, *ёлбогор болгох.*

ЁЛБОЙХ ёлбогор болох, улбагар улцгар болох.

ЁЛОЙЛГОХ ёлойхын үйлдүүлэх хэв.

ЁЛОЙХ ёлцгор ёлбогор болох.

ЁЛХГОНОХ ёлхгор юмны үргэлжлэн хөдлөх.

ЁЛХГОНУУЛАХ ёлхгонохын үйлдүүлэх хэв.

ЁЛХГОР гэдэс хэвэл нь хэвийн хэмжээнээс бүдүүн том; *ёлхгор гэдэстэй.*

ЁЛХДОС хүн амьтны уруу суулгахад гарах нусны адил зүйл.

ЁЛХДОСЛОХ ёлхдос гарах.

ЁЛХОЙЛГОХ ёлхойхын үйлдүүлэх хэв, ёлхгор болгох.

ЁЛХОЙХ хүн амьтны маш таргалж гэдэс хэвэл нь том болох; *ёлхойсон гэдэстэй хүн.*

ЁЛХОЛЗОХ ёлхгор юмны байн байн хөдлөх.

ЁЛХОЛЗУУЛАХ ёлхолзохын үйлдүүлэх хэв.

ЁЛЦГОНОХ ёлцгор юмны үргэлжлэн хөдлөх.

ЁЛЦГОР 1. юмны шингэн, нялцгар; улцгар; 2. хүний царай цагаан бөгөөд нимгэн; *ёлцгор царайтай;* 3. өвдсөн хүний бие төдий л сайжирч чадаагүй; *бие нь ёлцгор л байна;* 4. төрөлхийн бие чадал буурай хүн; *үгаасаа ёлцгор дорой амьтан даа.*

ЁЛЦОЙХ юмны ёлцгор болох; *хүүхдийн бие ёлцойгоод л байна.*

ЁЛЦОЛЗОХ ёлцгор юмны байн байн хөдлөх.

ЁМБОГОНОХ ёмбогор юмны үргэлжлэн хөдлөх.

ЁМБОГОНУУЛАХ ёмбогонохын үйлдүүлэх хэв.

ЁМБОГОР ёндгор; *ёмбогор хацар; ёмбогор толгой; ёмбогор хад; ёс ёмбогор, төр төмбөгөр з үй р.*

ЁМБОЙЛГОХ ёмбойхын үйлдүүлэх хэв, ёмбогор болгох.

ЁМБОЙХ ёмбогор болох; *толгой нь ёмбойж харагдав.*

ЁМБОЛЗОХ ёмбогор юмны байн байн хөдлөх.

ЁМБОЛЗУУЛАХ ёмболзохын үйлдүүлэх хэв.

ЁМБОН хэвийн жишээнээс ёмбогор байдалтай

ЁНДГОНОХ ёндгор юмны үргэлжлэн хөдлөх.

ЁНДГОНУУЛАХ ёндгонохын үйлдүүлэх хэв.

ЁНДГОР хэвийн жишээнээс овгор шонтгор юм; *ёндгор ташаатай морь; ёндгор бөгстэй үхэр.*

ЁНДОЙЛГОХ ёндойхын үйлдүүлэх хэв, ёндгор болгох.

ЁНДОЙХ ёндгор байдалтай болох; *ёндгор сандал; ёндгор бөгстэй морь.*

ЁНТГОНОХ ёнтгор юмны үргэлжлэн хөдлөх.

ЁНТГОР ёндгор, янтгар, шантгар; *ёнтгор зантай амьтан.*

ЁНТОЙЛГОХ ёнтойхын үйлдүүлэх хэв.

ЁНТОЙХ ёнтгор болох.

ЁНТОЛЗОХ ёнтгор юмны байн байн хөдлөх.

ЁНХГОНОХ ёнхгор амьтны ёнхго ёнхго хөдлөх.

ЁНХОГНУУЛАХ ёнхгонохын үйлдүүлэх хэв.

ЁНХГОР хонхгор; *ёнхгор нүдтэй.*

ЁНХИГОР хүн амьтны бие өндөр бөгөөд эцэнхий байдалтай; *ёнхигор ат; ёнхигор биетэй хүн.*

ЁНХИЙХ 1. ёнхигор болох; 2. эцэж турах, цонхийх; *царай зүс нь бүр ёнхийчихжээ.*

ЁНХОЙЛГОХ ёнхойхын үйлдүүлэх хэв, ёнхгор болгох.

ЁНХОЙХ 1. юм хөнхөр хонхгор болох; *нүд нь ёнхойх;* 2. юмны нүх сүв хонхойж харагдах; **ёнхойх хонхойх** х о р ш . .

ЁНХОЛЗОХ ёнхгор амьтны ёнхос ёнхос хөдлөх.

ЁНХОЛЗУУЛАХ ёнхолзохын үйлдүүлэх хэв.

ЁНХОР I ёнхгор, хонхор.

ЁНХОР II боловсруулсан мяндас; *цагаан ёнхор цацаг;* **ёнхор утас** (боловсруулсан мяндсан ширхгээр хийсэн утас).

ЁО өвдөхөд тэсэхгүй зовуурилан дуугарах аялга.

ЁОЗ I амьтан ба юмны дүр төлөв, үзэмж байр байц, чанар байдал; *ёоз муутай юм; ёозтой эд; байж байгаа ёоз нь тэр.*

ЁОЗ II даалууны хоёрхон нүхтэй мод; *аз байвал ёозоор хожно.*

ЁОЗГҮЙ 1. зан чанар ханилгаа ханш муутай; *ёозгүй хүн шүү;* 2. юмны үзэмж чанар зэхий муу, доожоогүй; *ёозгүй даавуу; ёозгүй царайтай морь.*

ЁОЗТОЙ зүгээр сайн, аятай, ёоз сайтай; *түүнтэй ярилцахад нэг л ёозтой биш байна.*

ЁОЛОХ хүний өвдөхөд тэсэхгүй ёо ёо гэж дуугарах.

ЁОТОН элсэн чихрийн шахмал, голцуу дөрвөлжин хэлбэртэй байдаг.

ЁОТУУ алх мэт бөгөөд том хоёр талдаа үзүүртэй зэвсэг, газар ухахад **хэрэглэнэ.**

ЁОХГОР шонхгор, ёнхгор.

ЁОХОР буриад ястны дуулан бүжиглэх бүжиг; *ёохор наадах.*

ЁОЧИН хатуу модоор гонзгой дөрвөлжин хайрцаг хийж, гуулин утсыг гулд тийш тэлэн татаж дэлдэн дуугарах хөгжмийн зэвсэг; хөгжмийн зэвсгийн их бага, утасны олон цөөний тоо харилцан адилгүй.

ЁОЧИНДОХ ёочин хөгжмөөр хөгжимдөх.

ЁР юмны сайн муу, бүтэх эсэхийн урьдаас сэрэгдэх тэмдэг; *муу ёртой юм болоод байлаа; ёр нь ороод байсан юм; сайны ёр биш;* **ёр орох** (ямар нэгэн хэргийн сайн муу болохын тэмдэг урьдаас сэрэгдэх).

ЁРГИО нэрэлхүү, хөөрөлхөг хүн; *энэ бас ёргио хүн шүү.*

ЁРГИУЛАХ ёргихын үйлдүүлэх хэв, ёргиход хүргүүлэх.

ЁРГИХ хэтэрхий хөөрөлхөх, сагсуу, хөөргөн зан байдал гаргах; *элдэв юманд ёргих хэрэг алга.*

ЁРДГОР хэвийн жишээнээс гонзгор, онцгор; *ёрдгор мод; ёрдгор хад.*

ЁРДОЙЛГОХ ёрдойхын үйлдүүлэх хэв, ёрдгор болгох.

ЁРДОЙХ ёрдгор болох.

ЁРДОЛЗОХ ёрдгор юмны ёрдос ёрдос хөдлөх.

ЁРДОЛЗУУЛАХ ёрдолзохын үйлдүүлэх хэв.

ЁРЛОХ сайн муу юмны ёр урьдаас үзэгдэх, сэрэгдэх, зөгнөгдөх; *ёр ёрлох.*

ЁРЛУУЛАХ ёрлохын үйлдүүлэх хэв.

ЁРОГ 1. нэхээс нь бүдүүлэг, нягт биш бүдүүн бөс даавуу; *ёрог даавуу; ёрог бүс;* 2. хээвэнтэй адил нэгэн зүйл бөс.

ЁРООЛ 1. авдар сав зэргийн юмны амсрын нөгөө этгээдийн битүү тал; *авдрын ёроол; хувингийн ёроол;* 2. уул мод зэргийн өндөрхөн юмны доод хажуу, орчин; *уулын ёроолын зам; модны ёроолд суув;* 3. далай нуур, мөрөн голын усны доод тал; *усны ёроолын амьтан; далайн ёроол;* 4. хэрэг заргын уг үүсгэл; *хэргийн ёроол; ёроол уудлан байцаах;* 5. тэрэгний хоёр хашлагын тушаа дундах газар; *хашлагын ёроол.*

ЁРООЛГҮЙ 1. гүн, гүнзгий; *ёроолгүй далай; ёроолгүй ус;* 2. юм тогтоодоггүй, ойлгодоггүй, тогтоох савгүй; *ёроолгүй хувин шиг тогтоох ёроолгүй амьтан.*

ЁРООЛДОХ 1. ёроолоос барих; **аяга ёроолдох** (цай ууж удаан суух); **хул ёроолдох** (айраг ууж удаан суух); 2. ёроолд хэтэрхий ойр болох; *уул ёроолдож нутаглах.*

ЁРООЛЛОХ 1. юманд ёроол хийх; *хувин ёрооллох;* 2. өндөр юмны ёроолоор зорчин явах; *ёрооллож явах.*

ЁРООЛЛУУЛАХ ёрооллохын үйлдүүлэх хэв.

ЁРООР ёроол.

ЁРООРЛОХ ёрооллох.

ЁРЧ зөнч, ямар нэгэн юмыг урьдаас мэдэж төсөөлөгч; *тун сайн ёрч хүн, намайг сургуульд явахыг сайн мэджээ.*

ЁС 1. юмны зайлшгүй зүй тогтоол, жам тавилан; *төрөх ёс; үхэх ёс; хувирах ёс;* 2. хүний дагаж баримтлах хэв хууль, журам зарчим, заншил суртал; *төрийн ёс; хууль ёс;* шажны ёс; боловсон ёс; *найр хуримын ёс; энэрэх элбэрэх ёс; зөв бурууғийн ёс; олон улсын ёс; ард түмний ёс; ёс мэдэхгүй хүнд ёр халдахгүй* з үй р; *ёс ёмбогор, төр төмбөгөр* з үй р; **ёс журам** (хэвшсэн тогтсон заншил суртал, зүй журам, дэглэм, зарчим; *ёс журмыг алдах; ёс журамтай хүн);* **ёс суртахуун** (хэвшсэн тогтсон зан суртал); **ёс заншил** (тогтсон хэв журам); **ёс дагах** (зүй журам, хэв суртлыг дагах; *ёс дагаж гүйцэтгэв);* **ёс баримтлах** (зүй журам, хэв суртлыг яг ёсчлон гүйцэтгэхийг хичээх): **ёс сахих** (а. зүй журам, хэв заншлыг баримтлан явах; б. хэв төвийг сахиж явах); **ёс хийх** (а. хүнтэй учрахад бие биесийг харилцан хүндэтгэж ёс гүйцэтгэх; б. аливаа ёс заншлыг ёсчлон гүйцэтгэх); **ёс гүйцэтгэх** (хэв журмыг дагаж баримтлан явах); **ёс алдах** (зүй журмаас гажуу явах; *хүндэтгэлийн ёсыг алдах);* **ёс бусчлах** (зүй журмыг дагахгүй, ёс бусаар хэлэлцэх, авирлах); **ёсноос гажуу, ёсноос ангид** (хэвшсэн тогтсон ёс журам, дэглэм зарчимд эс нийлэлцсэн); **албан ёсны** (хувийн биш, хууль зүйн дагуу хүчин төгөлдөр зүйл); **одоо цагийн ёс** (шинээр бий болж хэвшсэн тогтсон ёс журам); **салахын ёс хийх, үдэхийн ёс хийх** (а. зочин гийчнийг явах буцахад нь сүүлчийн мэнд хүргэх ёс гүйцэтгэх; б. нас нөгчигсдийг оршуулахын өмнөхөн эмгэнэлийн ёс гүйцэтгэх); **хагацах ёс хийх** (нас нөгчигсдийг оршуулахын өмнөхөн эмгэнэлийн ёс гүйцэтгэх); **ёсонд хазгар** (а. ёс журмаас гажуу; *би ч энэ өдөр ганц ёсонд хазгар хэрэг хийж орхив;* б. үнэнч шударга, ёс журмыг үгширтөл баримтлагч; *тэр гуай ч хэлсэндээ хүрэхгүй байх ч гэж харин ёсонд хазгар даа);* **ёсны юм** (бусдад бэлэглэх эд юм); **ёс төдий** (ор нэрийн төдий; *ажлыг ёс төдий гүйцэтгэх).*

ЁСГҮЙ 1. хүний ёс журам, заншил суртал нийлэхгүй, нийлүүлж чаддаггүй; *ёсгүй хэрэг; ёсгүй явдал; ёсгүй хүн;* 2. учиргүй; *тэр тийм байх ёсгүй; мэдэхгүй байх ёсгүй; чадахгүй байх ёсгүй.*

ЁСЛОГЧ ёс гүйцэтгэгч, хүндэтгэгч; *хүндэтгэн ёслогч тэр.*

ЁСЛОЛ ёслох үйлийн нэр; 1. аливаа тогтоосон дүрэм ёсыг дагаж гүйцэтгэх баяр цэнгэл дурсгалын зүйл; **баяр ёслол, жагсаал ёслол** х о р ш.; *ёслолын хурал; ёслол явуулах;* 2. уламжлалт заншил, газар орны жам суртлыг дагаж өргөмжлөх хүндэтгэх найр тавих зэргээр гүйцэтгэх ёс заншил; *ёслолоор үүлзах; найр тавих ёслол; хүндэтгэх ёслол;* **ёслолын жагсаал** (аливаа баяр ёслол, дурсгал, үгтах үдэх зэрэг хүндэтгэл бүхий цагт олноор ёслон гүйцэтгэх жагсаал); **ёслолын дүрэм** (аливаа ёслолд дагавал зохих тогтсон журам зарчим); **ёслолын хувцас** ёслолд өмсөхөөр тогтоосон тусгай хувцас); **ёслолын хэлтэс** (аливаа ёслолыг удирдах газар); **ёслолын буудлага** (ямар нэг чухал үйл явдлыг тохиолдуулан гүйцэтгэх хүндэтгэлийн буудлага); **ёслолын хаалга** (хүндэт зочны урин оруулах хаалга); **ёслолын үдэшлэг** (хүндэтгэлийн үдэшлэг).

ЁСЛОХ I. аливаа тогтоосон журам заншлыг гүйцэтгэн ёс ёслол үйлдэх, ёслох; *мэхийн ёслох; ёслон тэмдэглэх; ёсолж үдэх;* **2.** цэргийн хүн хоорондоо буюу ахлах дарга нараа хүндэтгэн баруун гараа толгойн тус газар ойртуулан өргөх; *гар өргөн ёслох.*

ЁСЛУУЛАХ 1. ёслохын үйлдүүлэх хэв; 2. ёслогдох.

ЁСООР тогтоосноор, журмаар, тогтоолоор, заавраар, бүрнээр; *хууль ёсоор шийтгэх; тушаал ёсоор гүйцэтгэх; тогтоол ёсоор биелүүлэх; таны хэлсэн ёсоор ирэв; тоо ёсоор авав.*

ЁСОРХОГ ёс журмыг хатуу баримтлагч.

ЁСОРХОХ ёсыг баримталж дагах.

ЁСОРХУУ ёсорхог.

ЁСТ ёс бүхий; **ёст хувцас** албан тушаалын хувьд тусгайлан өмсвөл зохих хувцас).

ЁСТОЙ 1. ёс бүхий, ёс журмыг баримтлан дагагч; *ёстой хүн; ёстой хэрэг; ёстой төртэй үйл;* 2. бодитой, зүйтэй, үнэхээр; *ёстой миний юм; ёстой зөв хэрэг; ёстой санадаг л санаа; ёстой сайн хүн; ёстой шинжгүй амьтан; ёстой муу хоол.*

ЁСЧЛОХ 1. аливаа ёс журмыг мөрдөх, дагаж журамлах; *ёсчлон дагах; ёсчлон дууриах;* 2. ёслох, мэхэсхийх; *ёсчлон мэхийв.*

ЁТУУ ятуу шувуу.

ЁУ I шаазан, сав, тоосго, ваарын зэргийг түлж боловсруулах шороо тоосгоор өндөр цогцлон хийсэн зуух.

ЁУ II: **ёу хас** хасын төрлийн маш гилгэр өнгөтэй, гэрэл бүхий нэгэн зүйл эрдэнийн чулуу.

ЁХ хүний бие зовох зүдэх насжих зэргээр бие суларч тамир алдарч өвдөх зэрэгт гаргах аялга; *ёх, ядарч байна!*

ЁХИВОЛЗОХ муу зан ааш гарган хохиволзох; *ялэ нэг амьтан ёхиволзоод л байна.*

ЁХИГОНОХ ёхиволзох, хохиволзох.

ЁХИР 1. хохиур муухай ааштай; 2. хэрдэг хэвцэг зантай.

ЁХИРДОХ хэтэрхий ёхир болох.

ЁХИРЛОХ ёхир зан байдал гаргах.

ЁХИУР ёхир хохиур; **ёхиур дохиур** х о р ш .

ЁХЛОХ ёх ёх гэж байн байн үглэх.

Ж

Ж монголын цагаан толгойн үсэг, Ж үсэг, Ж авиа.

ЖАА I хүндэтгэх хүний хэлсэн үг сургаалыг сонсон хүлээхэд хэрэглэх аялга; *жаа дагая; жаа мэдэв; жаа гүйцэтгэе.*

ЖАА II даалуугаар наадахад гурав буюу зургаан модыг ижил дүйзээр нь хос болгож тоглох тоглоом; *дан жаа; давхар жаа.*

ЖААД чанар муу, сайн биш; *жаад алт; жаад эд; жаад хүн.*

ЖААЗ I 1. зургийн гуу; **гуу жааз** х о р ш .; *зургийн жааз;* 2. сараалжлан хийсэн тавиур; *номын жааз.*

ЖААЗ II юмны адаг нь, муу нь, шаар нь; *жааз мал; хүний жааз,* зааз ч. гэнэ.

ЖААЗЛАХ I юмыг жаазанд хийх, жаазтай болгох; *зураг жаазлах.*

ЖААЗЛАХ II юмыг ялган салгаж адаг муугий нь үзэж ялгах; *мал жаазлах.*

ЖААЛ 1. бага жижиг; *жаал хүү; жаал дүү;* 2. **түр зуур**, баахан; *жаал азная; жаал яваад үзье.*

ЖААЛАХ даалуугаар жаа нийлүүлж наадах.

ЖААЛХАН жаахан; *жаалхан хүүхэд; жаалхан өгөөч.*

ЖААП х у у ч и р с а н сүм хийдэд дээд газраас шагнан олгосон нэр илэрхийлэл; *жаптай сүм.*

ЖААХАН 1. бяцхан, жижигхэн, бичилхэн; *жаахан хүүхэд; жаахан хурга; жаахан амьтан;* 2. түр, бага; *намайг жаахан хүлээ; номоо жаахан үншаад орхиё; жаахан хоол; жаахан өгөөч дээ.*

ЖАВ у р г а м а л урт нь хоёр чий, далайн хөвөөгөөр ургадаг, навч хатуу, таван салаа бүхий жижиг цэцэгтэй, үндэс гүйлсний үндэстэй адил, эмнэлэгт хэрэглэнэ.

ЖАВАА I у р г а м а л ар сүүдэр газар голдуу ургадаг, шүхэр адил улаан цэцэгтэй, тойр-

сон уртавтар навчтай ургамал, төрөл зүйл олон, үндсий нь эмнэлэгт хэрэглэнэ.

ЖАВАА II тооны нэр, арван сая, голди ч гэнэ.

ЖАВАР I жихүүн хүйтэн уур; *олон голын жавраас орны хөндийн жавар з үй р ; жавартай тэнгэрийн хаяа улаан, жаргалтай эхнэрийн хацар улаан, жалганд ургасан сухай улаан* (аман зохиолоос).

ЖАВАР II жалхаа, ёоз; **жалга жавар** х о р ш . ; *таны царай жавар мууτай байна; түүний нүд жавартай нүд шүү.*

ЖАВАРЛАХ жихүүн жавар үүсэх; *урдаасаа жаварлах; хойноос жаварлах.*

ЖАВАРЛУУЛАХ жаварлахын үйлдүүлэх хэв.

ЖАВГА амталж зуурсан гурилыг халуун хайруул дээр тавьж давтан давтсаар элдсэн гурил мэт нимгэн болгож боловсруулсан нэгэн зүйл идээ.

ЖАВДАН хурлын лам нарын суудлын урт өнгөц.

ЖАВРАЙ шингэн зуурсан гурилыг тосонд хайрч боловсруулсан нэгэн зүйл идээ.

ЖАВХАА өнгө үзэмж, толио; *жавхаатай хүн; жавхаатай морь; жавхаатай эд.*

ЖАВХААГҮЙ өнгө үзэмжгүй, золбоогүй.

ЖАВХААТАЙ өнгө үзэмжтэй, золбоотой; *энэ залуу мөн ч жавхаатай байна даа!.*

ЖАВХАЙХ жавхгар болох.

ЖАВХАЛЗАХ жавхгар юмны байн байн хөдлөх

ЖАВХАЛЗУУЛАХ жавхалзахын үйлдүүлэх хэв.

ЖАВХГАНАХ жавхгар юмны үргэлжлэн хөдлөх.

ЖАВХГАР нарийн биетэй цовоо хий морилог хөдөлгөөнтэй; *жавхгар унага; жавхгар гөлөг; жавхгар уурга.*

ЖАВХЛАН сүр хүчин, цог үзэсгэлэн, чанар үзэмж идтэй сайхан; **цог жавхлан, сүр жавхлан, золбоо жавхлан** х о р ш . ; *цог жавхлан нь бадарсан залуучуудын хөдөлмөр.*

ЖАВХЛАНГҮЙ жавхаа, жавхлан муутай, өнгө үзэмж муутай, золбоогүй; *яасан ч жавхлангүй юм бэ?.*

ЖАВХЛАНТ жавхлан бүхий, жавхлан төгөлдөр.

ЖАВХЛАНТАЙ жавхаа, жавхлан бүхий, жавхлан сайтай; *жавхлантай сайхан эр байна.*

ЖАВШААН ямар нэгэн зүйлийг гүйцэтгэхэд тохиолдох бололцоо, нөхцөл; *жавшаан тохиож ашиг олов; жавшаанаар уулзав; жавшаантай хэрэг болов;* **ашиг жавшаан** х о р ш . ; **жавшаан эрэх** (бололцоо, ашиг олохыг хичээх).

ЖАВШААНЧ жавшааныг эрэгч хичээгч.

ЖАВШААЧ хэтэрхий жавшимтгай.

ЖАВШААЧЛАХ хэтэрхий жавшаан эрэх, жавшааныг ашиглах.

ЖАВШИГДАХ жавшихын үйлдэгдэх хэв, жавшуулах.

ЖАВШИЛ жавших үйлийн нэр, жавшаан жавшсан юм.

ЖАВШИМТГАЙ арга нь олдвол жавших зантай.

ЖАВШИМХАЙ жавших зантай.

ЖАВШИХ юмыг төдий л бэрхшээлгүйгээр олох буюу бүтээх, хувьдаа ашиглах хэрэглэх; *улсын хөрөнгийг ашиглан жавших; бусдын юмыг замаас нь жавших; сохорсон биш жавших гэгчээр...*

ЖАВШЛАГА жавшаан, жавшил.

ЖАВШУУЛАХ 1. жавшихын үйлдүүлэх хэв, жавшихад хүргүүлэх; 2, жавшигдах.

ЖАВШУУР юмыг нууж далдлахгүй ярьчих зантай; *жавшуур хүн.*

ЖАГАР Энэтхэг, цагаан хятад.

ЖАГЖГАР ягжгар.

ЖАГЖЖҮҮВ у р г а м а л ой мод, голын эрэг, нуга намагтай газар ургадаг буурцагт ургамал, хөх цэцэгтэй, зарим нутагт төмөр дэгээ, ган дэгээ ч гэнэ.

ЖАГЖИЙХ жагжгар болох.

ЖАГСААЛ олноор жигдэлсэн эгнээ; *цэргийн жагсаал; биеийн тамирчдын жагсаал;* **ёслолын жагсаал** (цэргийн анги, биеийн тамирчид ёслолын байдлаар жигдрэн явах эгнээ): **сүрт жагсаал** (нийгэм улс төрийн бодлого шаардлагыг илэрхийлэн олноор жигдрэн явах эгнээ); **жагсаалын дарга** (ротын зохион байгуулалттай цэргийн ангийн бага тушаалын дарга нарын ахлагч); **жагсаалын цэрэг** (командлах бүрэлдэхүүнд үл оролцох цэргийн албан хаагч).

ЖАГСААЛТ жагсаасан юм; *нэрсийн жагсаалт; тооны жагсаалт; барааны жагсаалт; жагсаалт ёсоор.*

ЖАГСААЛЧ жагсаалыг тэгшлэх засах, сахих ба харгалзах хүн.

ЖАГСААХ 1. жагсахын үйлдүүлэх хэв, жагсахад хүргүүлэх; 2. дэс дараалан жигдрүүлэн зорчуулах буюу зогсоох, тавих, бичих зурах; *юмыг жагсааж өрөх; тоог жагсааж бичих; гишүүдийн нэрсийг жагсаах;* 3. үйл ажилд хэрэглэгдэх зүйлийг бүрдүүлэн бэлтгэж зэхэх; *газар ухахад хэрэглэх багаж хэрэгслийг жагсааж бэлдэв.*

ЖАГСАХ I 1. олноор зохион байгуулалттай эгнээ болж аливаа ёслол буюу сургууль үйлдэх, жагсаал хийх; 2. энгийн үеркэх зугаацах зэрэгт олон хүний жигдлэн явах буюу зогсох бөөгнөрөх.

ЖАГСАХ II нас шүд гүйцэх, *байргаших; жагссан шар; жагссан ирэг; нас шүд гүйцэж жагсах.*

ЖАД болдоор хийсэн хурц үзүүртэй хатгах зэвсэг; *морин жад; буюны жад;* **жад бялуу** (урьдын цагт түшмэлийн жагсаалд хэрэглэх зэвсэг, урт нь зургаан тохой, дээд тал нь шувтан, доод тал нь сартгар, хоёр захын өнгө хар, гол нь улаан будаг бүхий жад).

ЖАДААГУН х у у ч и р с а н таван эгшгийн гал махбод эгшиг.

ЖАДАНГА нэг зүйл ургамлын үр, эмнэлэгт хэрэглэнэ.

ЖАДАТ жад бүхий, жадтай.

ЖАДЛАХ юмыг жадаар чичих, хатгах.

ЖАДЛУУЛАХ 1. жадлахын үйлдүүлэх хэв; 2. жадлагдах.

ЖАДХА жалхаа, царай, үзэмж, жавхаа; *жадха сайтай; жадха муутай.*

ЖАЙВАЛЗАХ жайвгар юмны байн байн хөдлөх.

ЖАЙВГАНАХ жайвгар юмны үргэлжлэн хөдлөх.

ЖАЙВГАР яйжгар; жайзгар; *жайвгар түмпэн; жайвгар шанага.*

ЖАЙВИЙЛГАХ жайвийхын үйлдүүлэх хэв, жайвгар болгох.

ЖАЙВИЙХ жайвгар болох.

ЖАЙЖГАНАХ жайжгар юмны үргэлжлэн хөдлөх.

ЖАЙЖГАР яйжгар, майжгар; *жайжгар араг; жайжгар авдар.*

ЖАЙЖИГ жайжгар.

ЖАЙЖИЙЛГАХ жайжихын үйлдүүлэх хэв, жайжгар болгох.

ЖАЙЖИЙХ жайжгар болох.

ЖАЙЖИЛЗАХ жайжгар юмны байн байн хөдлөх.

ЖАЖУУР амьтны жавжийн хажуу орчин *жажууpаа хазах.*

ЖАЛАВЧ 1. тогоо нэрэхэд бүрхээрийн дээд этгээдэд тавьж, хүйтэн ус хийж халаадаг жижигхэн тогоо; зарим газар жижиг тогоог жалавч гэж нэрлэнэ; 2. хайв тогоо.

ЖАЛАН бариул этгээдийн оосроос барьж шидэх жад, агнуурт хэрэглэнэ.

ЖАЛАР муурын өөр нэр.

ЖАЛБАЛЗАХ нүдний цэцгий урваганан хөдлөх.

ЖАЛБИГАНАХ жалбигар юмны үргэлжлэн хөдлөх.

ЖАЛБИГАР ялтгар, ялбигар.

ЖАЛБИЙЛГАХ жалбийхын үйлдүүлэх хэв, жалбигар болгох.

ЖАЛБИЙХ жалбигар болох.

ЖАЛБИЛЗАХ жалбигар юмны байн байн хөдлөх.

ЖАЛГА байгалиас тогтсон суваг гуу; **жалга суваг, жалга гуу** х о р ш.; *баруун жалганд хунгар тогтжээ.*

ЖАЛГАЙ гол мөрний ус нэг хөвөөндөө гүн, нөгөө хөвөөндөө гүйхэн тийм газар.

ЖАЛГУУМЖТАЙ 1. эв эе сайтай, хэвээ сахисан, төлөв байдалтай; 2. ялгам зөөлөн явдалтай морь.

ЖАЛДАМ I цана хэрэглэхэд чадамгай сайн; *жалдам хүн.*

ЖАЛДАМ II нөмөр суваг, сархиаг бартаагүй мэлцийм цулгай газар; *жалдам газар; жалдам тал.*

ЖАЛМАГАНАХ аалигүйтэн өдөөж сэртгэнэх.

ЖАЛМАГАР 1. нүүр царайны байдал нимгэн шингэн жалжгар, *жалмагар охин;* 2. нүүр бөхтэй ичдэггүй.

ЖАЛМАЙХ 1. нүүр царай нь ил тод үзэгдэх; 2. ичгүүртэй явдал бий атлаа зовних бэрхшээхийг мэдэхгүй, үл мэдэхчин байх.

ЖАЛМАЛЗАХ 1. ичгүүртэй явдал хийсэн боловч ичих эмээхийг мэдэхгүй бөх нүүр гаргаж суух; 2. аалигүйтэх, сэртэндэх.

ЖАЛХ жавхаа, золбоо; **жалх жавхаа** х о р ш . ; *жалх муутай царай; жалх сайтай эд; жалхтай эр.*

ЖАМ юмны зайлшгүй тохиолдох зүй тогтоол; учрал тохиол; **жам ёс** х о р ш . ; *төрсний эцэст нөгчих нь жам; цагийн улирал ээлжлэх нь жам; орчиж байдаг нь орчлонгийн жам ёс, байгалийн жам.*

ЖАМБА у р г а м а л зам, ухсан нүх, тарианы шуудуу хашаа байшингийн орчмоор ургадаг нэг ба олон наст ургамал; төрөл зүйл олон, иш шулуун, навч нь дугарагдуу, цэцгийн өнгө нь ягаавтар, цэцгийг эмнэлэгт хэрэглэнэ.

ЖАМБИГАНАХ жамбигар юмны үргэлжлэн хөдлөх.

ЖАМБИГАР шамбигар, шамшгар; *жамбигар уруул; жамбигар ам.*

ЖАМБИЙЛГАХ жамбийхын үйлдүүлэх хэв.

ЖАМБИЙХ жамбигар болох.

ЖАМБИЛЗАХ жамбигар юмны байн байн хөдлөх.

ЖАМЪЯН: жамъян мядаг у р г а м а л холтсон цэцгийн язгуурын олон наст ургамал; цэцгийн дэлбэ цоморлогийн хамт шар буюу улбар шар, мөн цагаан байх нь ч бий, төрөл зүйл олон, эмнэлэгт хэрэглэнэ; **жамъян сэрвүү** у р г а м а л (жамъян мядаг цэцгийн нэг зүйл); **жамъян омбо** у р г а м а л (жамъян мядаг цэцгийн нэг зүйл); **жамъян гарвуу** у р г а м а л (жамъян мядаг цэцгийн нэг зүйл).

ЖАН I урт өндөр өргөн гүний хэмжээ, хос алд буюу 10 чий (3 метр); *гурван жан өргөн ус; хоёр жан гүн худаг; жангийн хивс; жангийн байшин.*

ЖАН II х у у ч и р с а н ялтныг жанчих зэвсэг, нэг үзүүр өргөн, нөгөө үзүүр нарийн, уртаар нэг метр орчим мод.

ЖАН III хоол амтлах хачир хольцоо, буурцгийг чанаж хатуу хөрөнгө болгон давс хольж хийнэ, амт нь бяцхан эхүүн бөгөөд исгэлэн давслаг.

ЖАН IV **жан яр** өнгөний дөрөвдүгээр өвчний нэр, тэмбүү ч гэдэг.

ЖАНГУАС давс жанд дарсан ногоо.

ЖАНГУАСЛАХ ногоог жан давсанд дарах.

ЖАНЖИН 1. бүх цэргийг буюу анги цэргийг ерөнхийлөн захирах албан тушаал; *бүх цэргийн жанжин; фронтын жанжин;* 2. эзэрхэл, ноёрхол; *ах наддаа жанжин.*

ЖАНЖЛАХ 1. цэргийг захиран командлах; 2. бусдыг хэтэрхий ноёрхох; *энэ хүн дэндүү жанжлаад байна.*

ЖАНЖЛУУЛАХ жанжлахын үйлдүүлэх хэв.

ЖАНЖУУСАА у р г а м а л модны хальсны дотоодод ургана, жимст долоон мөр бий, урт нь дөрөв таван тохой буюу метр хагас орчим, өнгө ногоовтор шар, амт амтайхан нэгэн зүйл жимс.

ЖАНЗ: жанз гүйлс у р г а м а л модонд ургана, өвөл навч нь зулгарахгүй, мах цөмийн гадуур ургана, амт амтайхан бөгөөд хүчтэй, бал чихэрт дарж иддэг нэгэн зүйл жимс.

ЖАНЗИЙ х у у ч и р с а н төрийн жүн вангийн угсаа залгамжлах хөвгүүн.

ЖАНЛАН а м ь т а н жоом хорхой, мөнгөний хорхой ч гэнэ.

ЖАНЛАХ жан банзаар жанчих дэлдэх.

ЖАНЧ (ИН) 1. бороонд нөмрөх ханцуйгүй нөмрөг хувцас; *бороony жанч;* 2. лам нарын нөмрөх хуниас гаргаж хийсэн хувцас; *торгон жанч; тэрмэн жанч;* **жанч халах, жанч арилжих** х у у ч и р с а н (лам нарын үхэхийн хүндэтгэл); **жанчин цэцэг** у р г а м а л (анарын цэцэгтэй адил таван хүйс овоололдон ургана; давхар тосгууртай, навч явцуу, өнгө сайхан, нэгэн зүйл цэцэг); **жанчин тахиа** (доголон ханчир гэдэг шувуу).

ЖАНЧИХ зодох, дэлдэх, цохих; **зодох жанчих** х о р ш . : *бусдыг жанчих гэдэг ул зохилдох явдал мөн.*

ЖАНЧУУЛАХ 1. жанчихын үйлдүүлэх хэв; 2. жанчигдах.

ЖАНЧУУР 1. газар зэргийг дагтаршуулахад хэрэглэх нүдүүр, түншүүр ч гэдэг; 2. цохих жанчихад зориулан хийсэн хэрэгсэл; *жанчуур мод; жанчуураар жанчих.*

ЖАР (АН) I 1. зургаан арав нийлсэн тооны нэр; *жаран адуу; жаран хоног;* 2. төвдийн зурхайн ёсны жаран жилээр хуваасан он тоолол; *арван зургаадугаар жарны хар бар жил;* **жаран хөлт** а м ь т а н (олон хөлтний ангийн үет хөлт шавьж, нэг үедээ нэг хос буюу хоёр хос хөлтэй, толгойдоо хоёр туршуултай; өвс, чулуу мэтийн юманд нуугдан далд оршино).

ЖАР II: жар жур хийх олон амьтны ам амандаа дуугарцгаах; *та нар битгий жар жур хийгээд бай!.*

ЖАРААД 1. жар орчим; *жараад бодтой; жараад төгрөг;* 2. тус бүр жар; *жараадаар нь* хуваах өг.

ЖАРААХАЙ 1. загасны нам, усанд оршино, бие нь маш жижигхэн; 2. загасны түрс зөвхөн хувилж анх загасны хэлбэр олоод байгаа үе; **загас жараахай** х о р ш..

ЖАРАВГАНАХ 1. жаравгар юмны үргэлжлэн хөдлөх; 2. сэртэндэн аалигүйтэх.

ЖАРАВГАНУУЛАХ жаравганахын үйлдүүлэх хэв.

ЖАРАВГАР нүдний аньсга нарийн буюу хөдөлгөөнтэй нүдтэй; *жаравгар нүдтэй хүүхэд.*

ЖАРАНТАА жаран удаа.

ЖАРВАЙХ жаравгар болох.

ЖАРВАЛЗАХ I 1. жирвэлзэх; 2. юмны тод бүдэх хольцон үзэгдэх.

ЖАРВАЛЗАХ II 1. жаравгар юмны байн байн хөдлөх; 2. аалигүй байдал гаргах.

ЖАРВАЛЗУУЛАХ жарвалзахын үйлдүүлэх хэв

ЖАРГА а м ь т а н умард мөсөн далай, зарим томоохон гол мөрний усанд орших загас, агнаж ашиглана.

ЖАРГААХ I жаргуулах.

ЖАРГААХ II жаргахад хүрүүлэх; **зул жаргаах** (зул жаргахад хүрүүлэх); **нар жаргаах** (нар жаргахыг хүлээх).

ЖАРГАЛ зовлонгүй, амар амгалан байгаа; *чөлөөт орны иргэн бүхэн жаргалтай; өргүй бол баян, өвчингүй бол жаргал* с э ц э н; **жаргал цэнгэл** (баяртайгаар жарган цэнгэлдэх).

ЖАРГАЛАН жаргах үйлийн хийсвэр нэр.

ЖАРГАЛАНТ жаргалантай.

ЖАРГАЛАНТАЙ жаргалан бүхий.

ЖАРГАЛГҮЙ зовлонтой, цэнгэлгүй, жаргаж чадахгүй; *тийм сайхан газар суух байгаад дандаа өвдөж байдаг ямар жаргалгүй хүн бэ?*

ЖАРГАЛТАЙ жаргал бүхий; *жартгай хүний нүд улаан, жаргалтай эхнэрийн хацар улаан* (аман зохиолоос).

ЖАРГАХ I 1. бие сэтгэл амгалан, аливаа үйлс эеэр нийлэлцэн байх; 2. зовуур зүдүүргүйгээр аятай байх.

ЖАРГАХ II 1. зарим юмны шингэх, унтрах; *нар жаргах; зул жаргах;* 2. хүндэтгэвэл зохих хүний унтах.

ЖАРГУУЛАХ жаргах I, II-ын үйлдүүлэх хэв.

ЖАРД х у у ч и р с а н шилдэг цэрэг, шадар цэрэг.

ЖАРДАМ цагийн хэмийн нэр, нэгэн инчидлийг арав хуваасны нэг буюу нэгэн нарийн хувь, секундийг арав хуваасны нэгтэй тэнцэнэ.

ЖАРДУГААР дэс дараалсан тооны жард тохиолдсон нь; *жардугаарт миний морь оров.*

ЖАРМАГАНАХ жармагар юмны үргэлжлэн хөдлөх.

ЖАРМАГАР I үс сахалгүй, жалмагар.

ЖАРМАГАР II дух хөмсгөө атируулалгүй тааламжтай харах байдал.

ЖАРМАЙЛГАХ жармайхын үйлдүүлэх хэв.

ЖАРМАЙХ I жармагар болох.

ЖАРМАЙХ II жалмайх.

ЖАРМАЛЗАХ I хүний тааламжтай байдлаа илрүүлж нүдээ талимаатуулан харах.

ЖАРМАЛЗАХ II жармагар юмны жармага жармага хөдлөх.

ЖАРТАЙЛГАХ жартайхын үйлдүүлэх хэв.

ЖАРТАЙХ нүдний аньсга жартгар болох, жарттай болон үзэгдэх.

ЖАРТАЛЗАХ 1. жартгар юмны байн байн хөдлөх; 2. нүд ирмэн анилхилан үзэх; 3. бусдад тааламжтай байдал гаргаж сэрэгдүүлэх.

ЖАРТВАЛЗАХ байн байн жарталзах.

ЖАРТГАЙ нүдний аньсга гадагш татагдан эргэсэн; *жартгай нүдтэй.*

ЖАРТГАНАХ жартгар юмны үргэлжлэн хөдлөх байдал.

ЖАРТГАР аньсга нарийн анигар; *жартгар нүдтэй.*

ЖАРУУЛ жаран тоотой юм хамт; *бид жаруул яваа.*

ЖАРХАЙ гярхай.

ЖАС I хурал номын сан хөмрөгийн газар; *цогчин жас; их жас;* **жас жав** х о р ш..

ЖАС II: **жас жас хийх** байн байн жас хийх.

ЖАСАА I 1. х у у ч и р с а н жилээс доош тогтмол хугацаагаар ээлж халалцан гүйцэтгэх албан үүрэг биед тохиолдох удаа; *жасаа авах; жасаа тохиолдох; жасаанд суух;* 2. мөн тогтмол хугацаагаар ээлж халалцан гүйцэтгэх албан байгууллага; *аймгийн жасаа; жанжин жасаа; суурин жасаа;* 3. тогтмол заншил болсон; *би халуун усанд сард нэг удаа ордог жасаатай; түүний манайд ирэх нь жасаа болсон юм.*

ЖАСАА II х у у ч и р с а н айл өрх шашны зан үйл ёсоор өөр өөрийн бурхан, сахиусыг тахиж хишиг буянаа дуудуулах тахилга; *жасаа уншуулах;* **жасаа даллага** х о р ш..

ЖАСААЛАХ х у у ч и р с а н ээлж дараатайгаар тогтмол хаах албанд суух буюу ямар нэгэн тогтмол болсон үйл ажлаа гүйцэтгэх; *тамгын газар жасаалан суух.*

ЖАСХИЙХ 1. биеийн ямар нэгэн газар сөнөрхөн жирдхийх; *хуруу жасхийтэл өвдөв; ялаа жасхийтэл хазав; жасхийтэл хатгах;* 2. нарийн шингэн дуугаар сочир дуугарах; *хүүхэд жасхийтэл уйлав;* 3. сүрхий, сайхан; *жасхийсэн халуун цай; жасхийсэн амттай хоол.*

ЖАХОР төвд нутагт байгаа монгол ястан.

ЖАЦ I у р г а м а л модны салааны үзүүрт ургадаг, тахианы эрхийн адил бөгөөд арай том, амт балын мэт амтайхан нэгэн зүйл жимс.

ЖАЦ II **жац давс** хлорт шүүтэр, давслаг амттай, үнэргүй, цагаан өнгийн нунтаг.

ЖАЯГ шашны лам нарын дотоод цааз; **цааз жаяг** х о р ш..

ЖИВ I: **ов жив; хов жив** 1. ов мэх, арга заль; *ов жив нь хэтэрсэн хүүхэд; ов живтэй амьтан;* 2. хов; **хов жив** х о р ш..

ЖИВ II нисэх хулганын өөр-нэр.

ЖИВАА жаваа.

ЖИВҮҮЛ өөшинд уяж усанд живүүлэх моголцог төмөрлөг; *загасны дэгээний живүүл.*

ЖИВҮҮЛЭХ живэхийн үйлдүүлэх хэв, живэхэд хүргүүлэх.

ЖИВХИЙХ 1. биед өртөс хатгах мэт аягүй болох; *тохойгоор живхийтэл хатгав;* 2. бусдад ямар нэгэн мэдээ зүйлийг сэм хүргэх; *мэдээ живхийлгэхгүй юу;* 3. ирт үзүүрт юмаар хатгах, чичих; *живхийтэл бүлэх.*

ЖИВХҮҮЛ живүүл.

ЖИВЭГ зэвэг.

ЖИВЭЛГЭХ улбариулах, хөлбөрүүлэх.

ЖИВЭР I 1. хүний дээд уруулд ургасан сахал; 2. сахлын хүндэтгэл.

ЖИВЭР II загасны нуруунд жигүүрийн адил ургасан бяцхан сэлбүүр; *загасны живэр.*

ЖИВРЭХ хүйтэн нойтонд даарсан мэт бие аягүй болох; *бие живрэх.*

ЖИВХНЭХ 1. төвхнөх, эмхрэх, цэгцрэх; *ажил живхнэх;* 2. татрах, хөнгөрөх; *хөлс живхнэх; бие живхнэх; морь живхнэх.*

ЖИВХРЭХ 1. эмхрэх, цэгцрэх; *ажил живхрэх;* 2. барагдах, багасах; *хөрөнгө живхрэх.*

ЖИВЭХ усанд хөвөхгүй доош далд орох; *хүнд юм живэхээс биш, хөнгөн юм живэхгүй; онгоц живэх; чулуу живэх.*

ЖИГ ямар нэгэн учир шалтгаан; ***жиг болох; жиг орох; жиг гарах;*** **жиг ургах** (үйл ажилд өөр учир шалтгаан бий болж саад хувирал тохиох); *цагтаа ирсэнгүй, нэг л жиг болж даа;* **жиг жиг хийх** (сэм инээлдэх); **жиг жуг хийх** (бусдын мууг сэм ярилцах).

ЖИГД I адил, тэнцүү, тэгш; *нэгэн жигд ургасан мод; жигд зэрэглэсэн жагсаал суудал; нэгэн жигд ажиллах; жигд болгох; жагд хөдөлгөөнтэй; жигд хуваах.*

ЖИГД II у р г а м а л цайвар голтой, хүрэн дурстай, ширхэг нарийн, чанар хатуухан нэгэн зүйл мод, үр жимс ургана, амт нь амтайхан.

ЖИГДЛҮҮЛЭХ жигдлэхийн үйлдүүлэх хэв, жигд болгуулах.

ЖИГДЛЭХ жигд болгох; *наад модоо ялгаад жигдлэчихээрэй;* **жигдэлсэн бишүүр** (арван хоёр бишүүр нэгэн дор нийлүүлэн багцласан хөгжим).

ЖИГДРҮҮЛЭХ жигдрэхийн үйлдүүлэх хэв, жигд болгох.

ЖИГДРЭХ 1. жигд, сануу болох; 2. юм бүрдэж гүйцэх; *жагсаал жигдрэх; ажил жигдрээгүй.*

ЖИГЖГЭР бие маш бяцхан хунхгүй; *жигжгэр биетэй хурга.*

ЖИГЖИГНЭХ 1. жигжгэр юмны үргэлжлэн хөдлөх; 2. бага зэрэг хазганах; *өвөл нь жигжигнэх янзтай харагдав.*

ЖИГЖИЙХ жигжгэр болох.

ЖИГЖИЛЗЭХ 1. жигжгэр юмны байн байн хөдлөх; 2. мэжилзэн доголох; *миний морины хөл жигжилзээд байна*; 3. сэтгэл догонцож жигхийх; *дотор жигжилзээд байна.*

ЖИГИЙНЭХ 1. явахад шулуун холхон одох; *жигийнэж явах;* 2. атирсан юмны сунах, тэнийх; *тэнийж жигийнэх;* 3. санаа сэтгэлийн зовнил тайлагдаж тавнун болох; *сэтгэл жигийнэн тайвширах.*

ЖИГЛЭХ 1. ичгүүртэй хэрэг учир бий атал нүүр жалмайн эс мэдэгчин байдал гаргах; *чи битгий жиглээд байгаарай;* 2. ямар нэгэн жиг учир бий болох; *жиглэцгээгээд та нар юу болж байгаа юм?*

ЖИГНҮҮЛЭХ I жигнэх I II-ын үйлдүүлэх хэв.

ЖИГНҮҮЛЭХ II 1. жигнэх III-ын үйлдүүлэх хэв; 2. жигнэгдэх.

ЖИГНҮҮР I юм жигнэх хэрэгслийн нэр, мод, төмөрлөгөөр ёроолд нь уур нэвтрэх нүх гаргаж хийнэ; *буузны жигнүүр.*

ЖИГНҮҮР II жин, жинлүүр.

ЖИГНЭГДЭХ жигнэх I II-ын үйлдэгдэх хэв.

ЖИГНЭМЭЛ жигнэн халааж болгосон юм; *жигнэмэл боов; жигнэмэл будаа.*

ЖИГНЭХ I 1. юмыг халуун уур буюу гал мэтэд халааж болгох; *бууз жигнэх; цай жигнэх;* 2. биед юмаар жин тавих; *халуун юмаар жигнэх; хүйтэн юмаар жигнэх; тостой даавуугаар жигнэх.*

ЖИГНЭХ II юмыг жингээр хэмжих; *гурил жигнэх; тос жигнэх.*

ЖИГНЭХ III бусдыг муутгах, нүүрий нь улайлгах үйл явдал битүүхэн хийх; *би ч түүнийг нэг удаа сайн жигнээд авсан даа.*

ЖИГТЭЙ ямар нэгэн гайхалтай учир, жиг бүхий; *жигтэй хэрэг байна даа!; жигтэй сонин явдал болов; яасан жигтэй юм бэ!.*

ЖИГТЭЙХЭН 1. жиг учир бий; 2. сонин гайхалтай..

ЖИГҮҮ төрлийн үе, жичинцрээс төрсөн хүүхэд буюу тавдугаар үеийн ач.

ЖИГҮҮР 1. шувууны далавч; 2. саадгийн мөрөвчний хойтох намианы дор хадсан төмөр; 3. жагсаал ёслол мэтийн төвлөрсөн юмны хоёр этгээд хажуу; *зүүн жигүүр; баруун жигүүр;* **жигүүр гэрэл** (их хаалганы хоёр захаар хөвөөлөн хийсэн гэрэл); **жигүүр хаалга** (их хаалганы хажуугийн бага хаалга); **жигүүрт хулгана** (багваахайн өөр нэр).

ЖИГҮҮРЛҮҮЛЭХ жигүүрлэхийн үйлдүүлэх хэв.

ЖИГҮҮРЛЭХ жигүүр болгох, жигүүр нь ургах.

ЖИГҮҮРТЭН жигүүр бүхий амьтны нийтийн нэр.

ЖИГХИЙХ айн хэлмэн санагалзах буюу жигшин зэвүүрхэх, жигжилзэх.

ЖИГШВЭРГҮЙ жигшихийг огт мэддэггүй.

ЖИГШИГДЭХ жигшихийн үйлдэгдэх хэв; *олноо жигшигдсэн этгээд; түмэнд жигшигдсэн, төрийн дайсан.*

ЖИГШИХ 1. хүний сэтгэлд нэндүү үл зохилдох зүйлийг ихэд голж дур гутан зэвүүрхэх санаа төрөх; *үнэрээс жигших; амьтнаас жигших; голж жигших; зэвүүцэн жигших; дайнаас жигших;* 2. амьтны ямар нэгэн юмнаас зэвүүцэж дошгирох; *тэрэгнээс жигшсэн морь; нохойгоос жигшсэн үхэр.*

ЖИГШМЭЭР хүн амьтан буюу юм хумын гуа цэвэр биш, муухай доройн байдал; *жигшмээр муухай амьтан; жигшмээр хэрэг; жигшмээр үнэр; жигшмээр амт.*

ЖИГШҮҮЛЭХ жигшихийн үйлдүүлэх хэв, жигшээх.

ЖИГШҮҮР I хүн амьтны үйл ааль муу буруу үзэгдэж гологдох гэзгдэх буюу шоод буруушаал хүлээх, нэр хүнд доройтохын нэр; *жигшүүр болсон этгээд; жигшүүр хүлээх.*

ЖИГШҮҮР II маш харамч; *жигшүүр амьтан.*

ЖИГШҮҮРГҮЙ жигшиж дур гутмаар биш юм; *жигшүүргүй үйл үйлдэж явсан дээр.*

ЖИГШҮҮРТЭЙ жигшүүр бүхий юм; *жигшүүртэй явдал; жигшүүртэй муухай хэрэг.*

ЖИГШҮҮРТЭН хүн амьтны нэгэнт жигшигдсэн нь.

ЖИГШЭЭХ жигшихэд хүрүүлэх, жигшүүлэх.

ЖИГЭНДИЙ инээдээ барьж чадаггүй хүн.

ЖИД шатар наадахад эсэргүүцлийн талыг нүүдэлгүй болгох хориг; *жид хийх; жидэд хорих.*

ЖИДЛЭХ шатраар наадахад эсэргүүцлийн этгээдийг нүүдэлгүй болгох.

ЖИДҮҮ I тац гэдэг мод.

ЖИДҮҮ II хүн амьтны биед үрэвсэн гарах нясуу яр, хамуу жидүү гэж холбон хэлэлцэнэ.

ЖИДҮҮ III эгдүү зэвүү; *жидүү хөдлөх; жидүүгий нь хүргэх.*

ЖИДҮҮРХЭХ зэвүүрхэх, эгдүүрхэх, эгдүү хөдлөх.

ЖИДҮҮРЭХ жидүү өвчин хүртэх.

ЖИДҮҮЦЭХ дур гутан зэвүүцэх.

ЖИЖИГ 1. ямар нэгэн юмны цогц бие хэвийн жишээнээс бага; *жижиг биетэй; жижиг ширхэгтэй; жижиг мал;* 2. үйл хэргийн том их биш, аар саар, бага сага; *жижиг хэрэг; жижиг үзэл бодол;* **жижиг хөрөнгөтөн** (эдийн засгийн талаар хүчин дорой бага хөрөнгөтөн; *жижиг аж ахуй*).

ЖИЖИГДҮҮЛЭХ жижигдэхийн үйлдүүлэх хэв, жижиг болгох.

ЖИЖИГДЭХ хэтэрхий жижиг болох; *жижигдээд тохиромжгүй байна.*

ЖИЖИГЛҮҮЛЭХ 1. жижиглэхийн үйлдүүлэх хэв; 2. жижиглэгдэх.

ЖИЖИГЛЭГДЭХ 1. жижиглэхийн үйлдэгдэх хэв; 2. гадуурчлагдах, гадуурхагдах, шоодворлогдох.

ЖИЖИГЛЭХ I юмыг жижиг болгох; мод жижиглэх; **жижиглэн худалдах** (ширхгээр буюу бага хэмжээгээр худалдаалах); **жижиглэн худалдах үнэ** (жижиглэн худалдахаар тогтоосон үнэ).

ЖИЖИГЛЭХ II гадуурчлах, гадуурхах, шоодворлох; *намайг, жижиглэх хэрэггүй.*

ЖИЖИГРҮҮЛЭХ жижигрэхийн үйлдүүлэх хэв.

ЖИЖИГРЭХ жижиг болох; *манай мал жижгэрч байна.*

ЖИЖИГХЭН арай жижиг, нилээд жижиг.

ЖИЖРЭГ шоодолтой хүн; *жижрэг хүнийг ичээж засах нь чухал.*

ЖИЖҮҮР ээлжийн журмаар үүрэг гүйцэтгэгч хүн; *жижүүр хийх; жир хүн биш, жижүүр хүн.*

ЖИЖҮҮРЛЭХ жижүүрийн ээлжийг хүлээж ажлыг гүйцэтгэх.

ЖИЖҮҮХИЙ хөөрхий гэж өхөөрдөн хэлэх үг; *жижүүхий хүүхэд.*

ЖИЙГҮҮЛЭХ жийгэхийн үйлдүүлэх хэв.

ЖИЙГЭНДИЙ амьтан нэг зүйл цох, биений урт нь 10—30 мм. өнгө бор, шар, саарал янз бүр, төрөл зүйл олон.

ЖИЙГЭХ I зарим жижиг амьтны дуугарах; *шумуул жийгэж байна.*

ЖИЙГЭХ II хурдлах; *зэрд морьтой хүн жийгээд хатираад айсуй.*

ЖИЙЛГЭХ жийхийн үйлдүүлэх хэв, жийхэд хүрүүлэх.

ЖИЙНГЭ I морины ам хатуу, довтлоход санасан газар авсаар зогсохгүй; *жийнгэ амтай морь.*

ЖИЙНГЭ II газар зам зэрэг зарим юмны завсархи бай зай нэгнээс нөгөө нь баахан хол буюу урт; *жийнгэ зам; жийнгэ газар; өрөөсөн зах нь жийнгэ эд.*

ЖИЙНГЭ III хүний хэвцэг зөрүүд зан байдалтай; *жийнгэ зангаа тат!.*

ЖИЙНГЭДЭХ хэтэрхий жийнгэ болох.

ЖИЙНГЭРЭХ жийнгэ болох.

ЖИЙРГЭВЧ жийргэлсэн юм; *тохмын жийргэвч; хөлийн жийргэвч.*

ЖИЙРГЭВЧЛЭХ жийргэвч болох, жийрэглэх.

ЖИЙРГЭМШИГТЭЙ аймшигтай, эмээлтэй, зүрхшээлтэй.

ЖИЙРГЭМШИХ айх, эмээх, бэмбэгнэх; *би багшаас нэг л жийргэмшгээд болдоггүй юм.*

ЖИЙРГЭНЭ ургамал навч шаравтархан бөгөөд хэв, иш суйхын адил, нэг төөгөөс өнгөрөхгүй, үхэр бөлжиргэнийн адил, жимс ургадаг.

ЖИЙРХЭХ 1. жийрэх, живрэх, жихүүцэх; 2. зэвүүцэх, эмээх, жигших; *танаас хүүхэд жийрхээд байна; би жийрхээд ойртож чадахгүй шүү.*

ЖИЙРЭГ 1. ямар нэгэн юмыг хамгаалах, гамнах, дулаалахын тулд хэрэглэсэн зүйл; *хөлийн жийрэг; хавхаг бөглөөний ороолт жийрэг; суудлын жийрэг;* 2. шилжсэн дэмжлэг, хамгаалалт, түшиг; *энэ над их жийрэг болж байгаа юм;* 3. хүндэтгэвэл зохих хүний цамц.

ЖИЙРЭГЛҮҮЛЭХ жийрэглэхийн үйлдүүлэх хэв.

ЖИЙРЭГЛЭХ жийрэг болгох, жийрэг хийх; *даавуугаар жийрэглэх.*

ЖИЙРЭХ 1. жихүүн хүйтэнд гэнэт бие сэгсрэн хөдлөх; 2. даарч бие тавгүй болох.

ЖИЙТАЙЛГАХ жийтайхын үйлдүүлэх хэв, жийтгар болгох.

ЖИЙТАЙХ жийтгар болох.

ЖИЙТАЛЗАХ жийтгар юмны байн байн хөдлөх байдал.

ЖИЙТАН жийтгар нүдтэй, анигар.

ЖИЙТГАНАХ жийтгар юмны үргэлжлэн хөдлөх.

ЖИЙТГАР нүдний аньсга нарийн анигар; *жийтгар нүдтэй.*

ЖИЙХ I хүн амьтны атирсан нугалсан хөлөө тэнийлгэх сунгах буюу хөлийн улаар хүчлэн тулах; *хөлөө жийж гараа сунган амарч байна.*

ЖИЙХ II жийнгэ зан байдал гаргах; *чи хэгжүүрхэн жийх хэрэг юун.*

ЖИЙХАЙЛГАХ жийхайхын үйлдүүлэх хэв, жийхгар болгох.

ЖИЙХАЙХ жийхгар болох.

ЖИЙХАЛЗАХ жийхгар юмны байн байн хөдлөх байдал.

ЖИЙХГАНАХ жийхгар юмны үргэлжлэн хөдлөх байдал.

ЖИЙХГАР нүдний аньсга нарийн жийтгар; *жийхгар нүдтэй хүүхэд.*

ЖИЛ I бүтэн арван хоёр сар буюу 365 (366) хоног; **өндөр жил** (нарны зурхайн ёсны 366 хоногтой жил); **шинэ жил** (жилийн эхлэлт өдөр; *шинэ жилийн баяр хүргэе!);* **жил гарах** (шинэ жил эхлэх); **жил хуучрах** (жил эхэлсэн цагаас холдож дараах **жил ирэх** шахам ойр болох); **арван хоёр жил** (сарны зурхайн ёсны жил сар өдөр цагийг ээлжлэн эзлэх арван хоёр амьтад); **хулгана жил** (сарны зурхайн ёсны хулгана эзэлсэн жил); **жилд, жилдээ; жилээр, жил дуусан, жил тойрон, жил турш** (нэгэн жил болтол буюу жилийн дотор); **ноднин жил** (өнгөрсөн жил); **ирэх жил, гарах жил, эсэргэн жил, хойтон жил** (дараагаар болох жил); **жил бүр, жил тутам, жил болгон** (жил жилд); **жил орох** (арван хоёр жилийн дотроос тэр хүний төрсөн жил нь дахин тохиолдох, арван гуравдахь жил дээр таарна, мөчлөг жил ч гэдэг); **жилийн төлөвлөгөө** (нэг жилд хийх ажлын төлөвлөгөө); **жилийн орлого** (жилийн дотор орсон орлого); **жилийн зарлага** (жилийн турш зарсан хөрөнгө); **таван жилийн төлөвлөгөө** (таван жилийн хугацаанд хийх ажил); **арван жилийн ой** (арван жил гүйцсэн өдөр); **жилтэй** (хүний төрсөн жил арван хоёр эрхтний аль нэг нь эзэлсэн жил тохиолдсон бол мөн тэрхүү эрхтний нэрээр тийм тийм **жилтэй** гэнэ: **хулгана** эзэлсэн жилд төрсөн хүнийг хулгана жилтэй гэхчлэн болно.

ЖИЛ II хугацаа удсан юмыг үл тааламжлан өгүүлэхэд хэрэглэнэ; *жил болж нэг юм ирэв үү.*

ЖИЛБЭ сая төллөсөн малын сүүн шим; *малын жилбэ сайнтай жил; төрөлхийн жилбэ муутай мал; нутаг тохирч малын жилбэ сайжрав;* **жилбэ орох** (жилбэ нь нэмэгдэх); **жилбэ суух** (жилбэших); **жилбэ төрөх** (аливаа үйл явдалд жавшилтай хэрэг тохиолдох).

ЖИЛБЭН I эдлэгээ явдалд зүдэрсэн **туурдсан** малын уяа сойлго алдсан, ус уусан, **халуун** ногоо идсэн, эмээл хомыг авч салхи чийг цохисон зэргээс олсон өвчний нэр; салхин жилбэн, усан жилбэн, хийн жилбэн, тосон жилбэн гэж ялгана, ихэвчлэн адуунд тусдаг.

ЖИЛБЭН II хүний гуяны дунд чөмөгний нарийн үзүүр орчим буюу өвдөгнөөс дээгүүрх хэсэг; **жилбэнгийн боолт** (морь унах хүний дотоод хормойгоо боох оосор).

ЖИЛБЭНДЭХ жилбэнгээс нь барих.

ЖИЛБЭНТҮҮЛЭХ жилбэнтэхийн үйлдүүлэх хэв.

ЖИЛБЭНТЭХ малд жилбэн өвчин тохиох.

ЖИЛБЭРХЭХ юмыг ихэд шунан хүсэх.

ЖИЛБЭТЭХ I жавшилтай юманд шимтэн шохоорох.

ЖИЛБЭТЭХ II аалигүйтэх, өдөөн сэртэнтэх.

ЖИЛБЭШИХ жилбэ орох шинжтэй болох, жилбэ суух.

ЖИЛДЭМ I ургамалгүй нүцгэн газар.

ЖИЛДЭМ II жалдам.

ЖИЛИЙ харгай модноос гарах нэгэн зүйл давирхай, байдал цавуу мэт наалдамтгай, өнгө улбар шаравтар.

ЖИЛИЙГЧ талийгаач, галийгч.

ЖИЛИЙГЭЭЧ жилийгч.

ЖИЛИЙДҮҮЛЭХ жилийдэхийн үйлдүүлэх хэв.

ЖИЛИЙДЭХ юманд жилий түрхэх.

ЖИЛИЙХ 1. юмны зайлан завхаж үгүй болох; *нохой хөөгөөд жилийв;* 2. хүний үхэх; **талийх жилийх** х о р ш . .

ЖИЛТНҮҮР өнгө гилбэгнэм шар нэгэн зүйл шир будаг.

ЖИМ I 1. маш нарийн ором зам; *малын жим дагаж явсаар ирэв;* 2. асга хадны явж болмоор мэт газар; *асганы жим; хадны жим.*

ЖИМ II газраас ухаж авсан зүлгэн хөрс.

ЖИМГЭР 1. амьтны ба сав суулганы ам амсар жоровгор бөгөөд зай багатай; *жимгэр урууллтай;* 2. дуугардаггүй. дуу цөөнтэй.

ЖИМИЙЛГЭХ жимийхийн үйлдүүлэх хэв.

ЖИМИЙХ 1. хүний уруул яг хавсрах; *уруулаа жимийх;* 2. үг дуугарахыг цээрлэсэн юм шиг байдал гаргах.

ЖИМНЭХ жимээр, мөрөөр замнаң явах.

ЖИМС 1. ургамлын идэж болох амтлаг үрийн алим анар мэт томхон, зүйл маш олон; 2. үр ба чихэр амтлагийн зүйлээр боловсруулсан зүйл; *чихэр жимс; чанамал жимс.*

ЖИМСГЭНЭ ургамлын идвэл болох амттайхан үрийн нэрс хад мэт жижгэвтэр, төрөл зүйл олон.

ЖИМСЛЭГ 1. жимс элбэгтэй; 2. жимс нь их.

ЖИМСЛЭХ 1. жимс нь ургах; 2. жимсий нь авах.

ЖИМССЭГ жимст дуртай.

ЖИМСТ жимс бүхий; *жимст мод; жимст уул.*

ЖИМСТЭЙ жимс бүхий, жимс элбэгтэй.

ЖИМСЭРХҮҮ 1. жимс ихтэй; 2. жимстэй төсөөтэй.

ЖИМСЭРХЭГ жимс ихтэй, жимс элбэгтэй.

ЖИМҮҮС ичгүүртэй явдал бий болович ичихгүй, үл мэдэгчин царай гаргаж байх нь.

ЖИМҮҮСЛЭХ ичгүүртэй явдал бий атлаа мэдээгүй царай гарган байх.

ЖИН I 1. хүнд хөнгөний хэмжээ; нэг жин нь 16 лан бөгөөд 600 граммтай тэнцэнэ; 2. хүнд хөнгөнийг мэдэх дэнсний адил бөгөөд том, иш туухайгаар бүрдсэн хэмжүүр; 3. хүнд хөнгөний багцаа; *жин хүндтэй ачаа; амьдын жин; цэвэр жин.*

ЖИН II аян, тээвэр; **аян жин, жин тээвэр** х о р ш.; *жин тээх; жингийн тэмээ.*

ЖИН III: **хувийн жин** ямар нэг биеийн жинг тухайн биеийн багтаамжтай тэнцүү бөгөөд цельсийн 4 градус усны жинтэй харьцуулсан жин.

ЖИН IV өвчин эмгэгийг анагаах засах арга; *халуун жин; хүйтэн жин; жин тавих.*

ЖИН V: **жин жин хийх** юмны байн байн жингэнэн дуугарах; *хонхны дуу жин жин хийж сонсдоно.*

ЖИН VI: **жин тан хийх** үйл ажилд хэрэглэгдэх зүйлийг бэлтгэн зэхэж гүйцэх; *би хамаг юмаа жин тан хийтэл бэлтгэсэн бөгөөд одоо явахад бэлэн байна.*

ЖИНГҮЙДЭЛ жингүйдэх үйлийн нэр.

ЖИНГҮЙДЭХ ямар нэгэн бие агааргүй орчинд ороход өөрийнхөө хүндийн жинг алдах; *жингүйдэх байдалд орох.*

ЖИНГЭНЭМ ясанд даамжиртал жихүүцүүлэх хүйтэн, жингэнэм жихүүн ч гэнэ; *жингэнэм жавар хацар хайрах шиг болов.*

ЖИНГЭНЭХ I нарийн шингэн дуутай юмны удаан дуугарах; *төмөр жингэнэх; хонх жингэнэх; салхи жингэнэх.*

ЖИНГЭНЭХ II жихүүн хүйтэнд бие махбод нэвтэртэл хөрч даарах; *хүйтэн жингэнэж байна.*

ЖИНГЭР I өлөгчин нохой, гичий нохой.

ЖИНГЭР II: **жингэр жингэр хийх** төмөрлөг эдлэлийн харшин дуугарах дуу; *гинж жингэр жингэр дуугарч байна.*

ЖИНД бодитой, чанар сайн; *жинд мөнгө; жинд торго.*

ЖИНДҮҮ I жихүүцэм, даарам хүйтэн; *галгүй байшинд удаан суухад баахан жиндүү байв.*

ЖИНДҮҮ II тэрэг годилдохоос хамгаалах нэг зүйл тоног хэрэгсэл.

ЖИНДҮҮЛЭХ жиндэхийн үйлдүүлэх хэв, жиндэхэд хүргүүлэх.

ЖИНДҮҮХЭН арай жиндүү, нилээд жиндүү.

ЖИНДЭХ хүйтэнд жигнэгдэн жихүүцэх.

ЖИНЖҮҮ хүзүүнд зүүх эрх мэт нэг зүйл чимэг.

ЖИНЛҮҮР 1. хүнд хөнгөний хэмжээг хэмнэн мэдэх хэрэгслийн нийт нэр; *жинлүүр чинлүүр;* 2. жин хэмжүүр.

ЖИНЛЭХ хүнд хөнгөнийг хэмжүүрээр хэмжих; *ноос жинлэх; тос жинлэх.*

ЖИНС малгайн сампан; урьдын цагт төр шашны ямба хэргэмтэн нарын малгайн сампанг чулуу, шүр, шил зэргээр хийдэг байв.

ЖИНТҮҮ хүний дэрлэх түших хэрэгсэл, эд бөсөөр уут мэт сав хийж, дотор нь хөвөн, буурцаг, өд өвс зэргийг чихэж хийнэ, чихээст дэр ч гэнэ; *жинтүүний булан.*

ЖИНТЭЙ 1. нилээд хүндхэн чанартай; жинтэй эд; 2. зан санаа тогтвортой, юмыг бодож мэдэх нь суурь сайтай; *нилээд жинтэй хүн.*

ЖИНХЛҮҮЛЭХ жинхлэхийн үйлдүүлэх хэв.

ЖИНХЛЭХ 1. албан тушаалын чухам орныг эзлэн хүлээх; *ажилд жинхлэх; дарга жинхлэх;* 2. чухам гишүүн болон багтах; *намд жинхлэх; гишүүнд жинхлэх.*

ЖИНХЭНЭ чухам; *жинхэнэ тушаал; жинхэнэ сайд; жинхэнэ эд; жинхэнэ гишүүн; жинхэнэ чанар.*

ЖИНЧИН жин тээж яваа хүмүүс.

ЖИР I энгийн; *жир хүн;*

ЖИР II: **жир жир хийх** 1. булгийн ус зэрэг шингэн юм өчүүхэн өчүүхнээр ундарч оргин гарах; *жир жир урсах;* 2. болжмор зэрэг жижиг шувууны дуугарах; *жир жир жиргэх;* 3. хүний биений энд тэнд жирвэг жирвэг хийх; *бие жир жир хийв.*

ЖИРВИЙ сахал мэтийн юмны тэгш, нарийн; *жирвий сахалтай.*

ЖИРВИЙЛГЭХ жирвийхийн үйлдүүлэх хэв.

ЖИРВИЙХ жирэвгэр болох буюу жирвийн үзэгдэх.

ЖИРВЭГНҮҮЛЭХ жирвэгнэхийн үйлдүүлэх хэв.

ЖИРВЭГНҮҮР зэрэглээний адил болоод цайвгар өнгөтэй хоосон үзэгдэл.

ЖИРВЭГНЭХ жирэвгэр юмны үргэлжлэн хөллөх.

ЖИРВЭГЭР нарийн бөгөөд жиргэр юм; *жирвэгэр сахал; жирвэгэр хөмсөг; жирвэгэр нүд.*

ЖИРВЭЛЗҮҮЛЭХ жирвэлзэхийн үйлдүүлэх хэв, жирвэлзэхэд хүргүүлэх.

ЖИРВЭЛЗЭХ жирвэгэр юмны байн байн хөдлөх.

ЖИРГҮҮЛЭХ жиргэх I II-ын үйлдүүлэх хэв.

ЖИРГЭР юмны дүрс байдал жижиг бөгөөд жигдэрсэн жагссан мэт төлөв; *жиргэр нарийн бичиг зураг; хол үзэгдэх жиргэр юм; жиргэр өөдол.*

ЖИРГЭХ I болжмор богширго зэрэг жижиг шувуудын дуугарах.

ЖИРГЭХ II юмыг жижиглэн хэсэглэх; *мах жиргэх; түлээ жиргэх.*

ЖИРГЭХ III жирэг гэдэг тоглоомоор наадах.

ЖИРГЭХ IV хуучирсан дээд хүнтэй дэмий үг булаалдан цэцэрхэх.

ЖИРИЙЛГЭХ жирийх I II-ын үйлдүүлэх хэв.

ЖИРИЙХ I юмны жиргэр болох, үзэгдэх.

ЖИРИЙХ II гүйх, хурдлах; *хүүхэд жирийх; зээр жирийх.*

ЖИРМИЙЛГЭХ жирмийхэд хүргүүлэх.

ЖИРМИЙХ нүдээ өчүүхэн завсарласхийн үзэх.

ЖИРМЭГНЭХ жирэмгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ЖИРМЭЛЗЭХ жирэмгэр юмны байн байн хөдлөх.

ЖИРС: жирс жирс хийх юмны хоромхон зуур байн байн хөдлөн үзэгдэх, харагдах.

ЖИРСХИЙХ 1. хоромхон зуур биед цахилгаан гүйх мэт мэдрэгдэх; *дотор жирсхий-гээд л явчихав;* 2. жиргэр юмны хоромхон зуур үзэгдэн өнгөрөх; *жирсхийн үзэгдэх; тийрэлтэт онгоц жирсхийн өнгөрч байв.*

ЖИРХ амьтан ой модонд оршдог, модонд асах харайхдаа сайн, нуруундаа хар судалтай амьтан, бие нь хулганатай адил, арьсы нь ашиглана.

ЖИРХИЙХ түр зуур жирэлзэх; *булчин жирхийх.*

ЖИРХҮҮ ургамал өвсөн иштэй, жирхрээд адил цэцэгтэй, 1—2 хуруу урт, өнгө шаравтар ногоон ургамал.

ЖИРХРЭХ жирхрээгийн дуугарах, чаргаг дуун гарах.

ЖИРХРЭЭ амьтан өнгө бараан, нуруу хальстай, жигүүр нь урт, модонд сууж дуугардаг нэгэн зүйл хорхой.

ЖИРЭВ: жирэв жарав хийх юмны бүрэг бараг үзэгдэх байдал.

ЖИРЭВГЭР сахал ус мэтнийн юмны нарийн, ширүүвтэр; *жирэвгэр сахалтай.*

ЖИРЭВХИЙХ юмны маш түргэн үзэгдэн өнгөрөх; *цахилгаан жирэвхийв.*

ЖИРЭГ хөлөгт цах тавьж наадах наадмын нэр, 82 цахыг хоёр хүн адил тоогоор хуваан барьж шатрын хөлөгт тавьж наадах нэг зүйл, тусгай хөлөгт 24 цах тавьж наадах ийм хоёр зүй бий.

ЖИРЭГНҮҮЛЭХ жирэгнэхийн үйлдүүлэх хэв.

ЖИРЭГНЭХ жиргэр юмны үргэлжлэн хөдлөх байдал; *ус жирэгнэн урсах.*

ЖИРЭЛЗҮҮЛЭХ жирэлзэхийн үйлдүүлэх хэв.

ЖИРЭЛЗЭХ жиргэр юмны байн байн хөдлөх.

ЖИРЭМ эмээлийн олмыг чангалдаг гөрмөл сур; *олом жирэм; гурамсан жирэм;*

ЖИРЭМГЭР хүний нүдний байдал ердийнхөөс нарийн зуравгар болоод гадаад булан дээш сөлгөр.

ЖИРЭМСЛЭХ эмэгтэй хүний бие шалтгаатай болох.

ЖИРЭМСЭН эмэгтэй хүний бие шалтгаатай болсон нь; *жирэмсэн эмэгтэй;* **жирэмсний амралт** (бие шалтгаатай болсон эмэгтэйчүүдэд хууль ёсоор олгох амралт).

ЖИХРЭХ 1. хүйтэнд бие жихүүцэх; 2. **чаргаг** дуун дуугарах.

ЖИХҮҮН халуун дулаан гэдэгтэй эсэргүүцэлдсэн утга; I. агаар амьсгалын хүйтэн сэрүүн; *хүйтэн жихүүн газар орон; сэрүүн жихүүн цаг улирал;* 2. юманд хүйтэн сэрүүний чанар халдаж хүрсэн нь; *жихүүн хүйтэн идээн ундаа;* **жихүүн булаг** (маш хүйтэн устай булаг): **жихүүн салхи** (тасхийм хүйтэн салхи).

ЖИХҮҮРХЭХ жихүүнээс болж бие аягүй болох.

ЖИХҮҮРЭХ 1. хүйтрэх, хүйтэц болох; 2. халуун юм хөрөх; 3. даарснаас олж бие аягүй болох.

ЖИХҮҮЦҮҮЛЭХ жихүүцэхийн үйлдүүлэх хэв.

ЖИХҮҮЦЭХ 1. хүйтэнд баахан даарах; 2. ямар нэгэн шалтгаанаар бие даарах мэт болох; 3. хүндэтгэвэл зохих хүний даарах; 4. халуун юм биед хүрч баахан халах; 5. дургүй хүрэх, **дургуйцэх.**

ЖИЧ I 1. бас, анги́д, тусгай; *жич хэлэх нь; жичид нь ярилцах ёстой;* 2. өөр; *тэр бол жич асуудал; жич хэрэг.*

ЖИЧ II ачид төрсөн хүүхэд; *манай жич хүү.*

ЖИЧИНЦЭР гучид төрсөн хүүхдийг буюу дөрөвдүгээр үеийн ач.

ЖИШИГ 1. ямар нэгэн хэмжигдэхүүнийг заасан зураг; *малын өсөлтийг харуулсан жишиг;* 2. үлгэр, жишээ, журам; 3. адил, ижил, ойр.

ЖИШИМ: **жишимгүй байх** тоохгүй, мэдрэхгүй, анхаарахгүй, ажиггүй байх.

ЖИШИХ I юмыг урьдаас төлөвлөн зэхэж бэлтгэх, байрлуулах; *эд хэрэглэхүүнийг төсөвлөн жиших; өртөө буудал жиших.*

ЖИШИХ II ямар нэгэн юмыг өөр зүйлийн үлгэр журмаар адилтгах; *үлгэрлэн жиших; бодож жиших; хүнд хөнгөнөөр нь жиших.*

ЖИШИХ III гажих, таших; *замаас бүр жишээд явчихлаа шүү дээ.*

ЖИШЛЭХ хатсан ангасан юмыг дэвтээх, чийглэх; *арьс жишлэх; ам жишлэх.*

ЖИШҮҮ ташуу; *жишүү талтай дөрвөн өнцөгт;* **жишүү харах** (буруулан харах).

ЖИШҮҮДЭХ хэтэрхий жишүү болох.

ЖИШҮҮЛ 1. ямар нэгэн үйл явдалд хэрэглэгдэх зүйлийг урьдчилан бэлтгэх зэхэх ажлаар томилогдсон хүн; *жишүүл элч;* 2. шавга гүйлгэн эргүүл манаа хийж байгаа хүн; 3. зааж туслалцах хүн; *бөхийн жишүүл; засуулч ч гэдэг.*

ЖИШҮҮЛЭХ жишихийн үйлдүүлэх хэв.

ЖИШЭЭ 1. үлгэр, загвар, жишиг; **үлгэр жишээ, загвар жишээ** х о р ш.; 2. адилтгал; *харьцуулсан жишээ; зэрэцүүлсэн жишээ;* 3. баримт; **жишээ баримт, баримт жишээ** х о р ш..

ЖИШЭЭЛҮҮЛЭХ жишээлэхийн үйлдүүлэх хэв.

ЖИШЭЭЛЭХ баримт үлгэр болгох, адилтган үзэх; *жишээлэхэд; жишээлбэл; үүнийг түүнтэй жишээлж яаж болох вэ.*

ЖОВ нохойг зандрах хөөхөд хэлэх аялга.

ЖОВГОН нэгэн зүйл оромж.

ЖОДГОР бөс даавуугаар дөрвөлжин босоо хэлбэртэй хийсэн оромж, майхан; **майхан жодгор** х о р ш..

ЖОДОО у р г а м а л нарсны язгуурын мөнх нэгэн шинжүүст мод, боргоцой нь шулуун бөгөөд гойзгойвтор, жодоог барилгын материалд хэрэглэнэ.

ЖОЛОМ урц, оромж.

ЖОЛОО 1. эдлэгээний морь малын хазаарын зуузайд уясан залж удирдах оосор; **жолоо цулбуур** х о р ш.; *моринь жолоо;* 2. удирдан залж чиг олгох юм; **жолоо залуур** х о р ш.; *машины жолоо; төрийн жолоо.*

ЖОЛООДЛОГО жолоодох үйлийн нэр; *намын мэргэн жолоодлогын дор явж өөрийн зорилтыг биелүүлнэ.*

ЖОЛООДОГЧ тэргүүлэн удирдах газар, хүн; *улсыг жолоодогч нам; ард түмний жолоодогч.*

ЖОЛООДОХ 1. ямар нэгэн үзэл суртал, үйл явдлыг удирдан зааварлаж чиглүүлэх; *удирдан жолоодох; сурган жолоодох;* 2. морь малын жолоогоос барьж удирдан залах; *морь тэрэг жолоодох;* 3. машин техник зэргийг жолоочлон явах; *машин жолоодох; нисэх онгоц жолоодох.*

ЖОЛООДУУЛАХ 1. жолоодохын үйлдүүлэх хэв; жолоо бариулах; 2. жолоодогдох.

ЖОЛООЧ жолоо залуурыг барьж явуулах жолоодох хүн; *нисэх онгоцны жолооч; трактерын жолооч; даргын жолооч.*

ЖОЛООЧЛОХ жолоочийн ажил үүргийг хүлээн ажиллах.

ЖОМБОГОНОХ жомбогор юмны үргэлжлэн хөдлөх.

ЖОМБОГОНУУЛАХ жомбогонохын үйлдүүлэх хэв.

ЖОМБОГОР цомцгор, шомбогор; *жомбогор хушуутай хурга; жомбогор толгойтой.*

ЖОМБОЙЛГОХ жомбойхын үйлдүүлэх хэв.

ЖОМБОЙХ жомбогор болох.

ЖОМБОЛЗОХ жомбогор юмны байн байн хөдлөх.

ЖОМБОЛЗУУЛАХ жомболзохын үйлдүүлэх хэв.

ЖОН: жон жон хийх хүний байн байн нөрөн хэлэлцэж, авсаар салахгүй болох; *чи битгий жон жон гээд бай.*

ЖОНГЛЁР түргэн шаламгай хөдлөн юмыг шидэж, барьж авах гарын эрдэм; *жонглёр хийх.*

ЖОНТГОНОХ жонтгор юмны үргэлжлэн хөдлөх.

ЖОНТГОР шонтгор, жомбогор.

ЖОНТОЙЛГОХ жонтойхын үйлдүүлэх хэв.

ЖОНТОЙХ жонтгор болох.

ЖОНТОЛЗОХ жонтгор юмны байн байн хөдлөх.

ЖОНХГОР шонхгор, жонтгор.

ЖОНХОЙЛГОХ жонхойхын үйлдүүлэх хэв, жонхгор болгох.

ЖОНХОЙХ жонхгор болох.

ЖОНХУУ юм наахад зориулан шингэн бууцалгасан гурил; *жонхуу хийх.*

ЖОНХУУДАХ 1. юманд жонхуу түрхэх; 2. юмыг жонхуугаар наах.

ЖОНХУУЛАХ жонхуу болгох; *гурил жонхуулах.*

ЖОНХУУРАХ жонхуу шиг болох, наалданги болох; *гурилтай хоол жонхуурах.*

ЖОНХУУШИХ юмны хувирч жонхуу шинжтэй болох; *хоол жонхууших.*

ЖОНШ жоншны төрлийн чулуулгийн ерөнхий нэр; **хайлуур жонш** (нэг зүйл жонш, өнгө олон янз, шар атлаа улаан туяатай, ногоон, улаан байхаас гадна бас өнгөгүй, тунгалаг ч бий; зарим нь талсттай, төмөрлөг хайлуулахад орно); **хэрийн жонш** (элбэг тохиолддог нэг зүйл жонш; шил, шаазан, ваарын хольц, цахилгаан үл дамжуулах эдлэл хийхэд хэрэглэнэ); **шохойн жонш** (элбэг тохиолддог нэг зүйл жонш; энэ жоншны тунгалгаас шилж дуран авайн шил зэрэг зүйл хийнэ).

ЖООМ а м ь т а н ариун цэвэрч биш байснаас орон сууцанд бий болдог нэгэн зүйл шавьж; жанлан, **мөнгөний хорхой** ч гэдэг.

ЖООТГОНОХ жоотгор юмны үргэлжлэн хөдлөх.

ЖООТГОНУУЛАХ жоотгонохын үйлдүүлэх хэв.

ЖООТГОР онигор бага нүдтэй; *жоотгор нүдтэй хүн.*

ЖООТОЙЛГОХ жоотойхын үйлдүүлэх хэв, жоотгор болгох.

ЖООТОЙХ жоотгор болох.

ЖООТОЛЗОХ жоотгор юмны байн байн хөдлөх.

ЖООТОЛЗУУЛАХ жоотолзохын үйлдүүлэх хэв.

ЖООТОН жоотгор; *зааны нүд жоотон байдаг.*

ЖОР найруулах арга заавар; *эмийн жор, хоолны жор; жор мэдэхгүй эмчээс зовлон үзсэн чавганц дээр* з ү й р.

ЖОРЛОН бие засах газар.

ЖОРЛОХ жорын ёсоор найруулах; эм жорлох.

ЖОРЛУУЛАХ жорлохын үйлдүүлэх хэв, жортой болгох.

ЖОРОВГОР цоровгор, шоровгор; *жоровгор хушуутай хүүхэд.*

ЖОРВОЙХ цорвойх, шорвойх; *жорвойсон уруултай.*

ЖОРВОЛЗОХ жоровгор юмны байн байн хөдлөх, цорволзох, шорволзох.

ЖОРВОЛЗУУЛАХ жорволзохын үйлдүүлэх хэв, жорволзоход хүргүүлэх.

ЖОРОО адуу морины нэгэн зүйл явдлын нэр; нэгэн алхамдаа зүүн этгээдийн хоёр хөл, нөгөө алхамдаа баруун этгээдийн хоёр хөлийг тус тус зэрэг гишгэж сайвраас хурдан явах явдал; *жороо морь; жороо илжиг.*

ЖОРООЛОХ жороо явдлаар явах.

ЖОРООЛУУЛАХ жороолохын үйлдүүлэх хэв.

ЖОУ х у у ч и р с а н хааны зарлиг; **жоу бичиг** (хааны зарлигийн бичиг).

ЖӨТГӨӨР х у у ч и р с а н нэг хүний хоёр эхнэр; *жөтгөөр эхнэр.*

ЖӨТӨӨ атаа, өш хонзон; **атаа жөтөө** х о р ш.; *жөтөө нь хэтэрвэл чөтгөр болно.*

ЖӨТӨӨР жөтгөөр.

ЖӨТӨӨРХӨГ жөтөөрхүү зантай.

ЖӨТӨӨРХӨХ атаархах зан байдал гаргах.

ЖӨТӨӨРХҮҮ хэтэрхий жөтөөч.

ЖӨТӨӨРХҮҮЛЭХ жөтөөрхөхийн үйлдүүлэх хэв.

ЖӨТӨӨЧ хэтэрхий жөтөөрхүү.

ЖУГАР у р г а м а л гойд тэсвэртэй **тэжээ**лийн нэг наст ургамал, чанарааараа эрдэнэ шиштэй бараг адил, хатаах буюу даршилж хэрэглэнэ.

ЖУГУУЛЧ (ИН) жуулч .

ЖУГУУЛЧЛАЛ жуулчлал.

ЖУГУУЛЧЛАХ жуулчлах.

ЖУГУУЛЧЛУУЛАХ жуулчлахын үйлдүүлэх хэв.

ЖУГУУХ жуух.

ЖУДАГ төлөв байдал, зан чанар.

ЖУДАГГҮЙ хүний зан, санаа, томоо тогтуур муу урвамтгай, шудрага биш байдалтай; *жудаггүй хүн; жудагдагүй амьтан.*

ЖУДАГТАЙ ханилгаа сайтай, нөхрийн ханш сайтай; *жудагтай сайн нөхөр.*

ЖУНДАН саатай торго.

ЖУНДАР х у у ч и р с а н тосгоны дарга.

ЖУНЗ улаан чавгатай хольж агшаасан тутрага будаа.

ЖУРАМ I 1.хууль, зүй, хэв суртлыг дагаж тогтсон ёс зарчим; **ёс журам, суртал журам, хэв журам, заншил журам** х о р ш.; *манай дотоод журам; журам алдах; нийтийн ёс журам; сахилга журам; намын ерөнхий журам;* **журам болгох** (хэвшил болгож баримтлах); **нийгэм журам** (социализм); 2. эд юманд татсан зурсан зурдас шугам; **шугам журам** х о р ш.; *дэвтрийн журам; журамтай цаас бөс;* 3. юмны нэг зурвас; *журам бөс; журам цаас; журам даавуу; голын журам;* 4. зан суртлын шудрага чигч, томьёолог түвшин нь; *найрал журам; эв журам; нөхрийн журам;* **„шудрага журам медаль"** (гэнэтийн осол аюулаас улс, олон нийтийн хөрөнгө ба хүний амь биеийг аврах хэрэгт онцгой гавьяа байгуулсан иргэдийг шагнах тэмдэг).

ЖУРАМ II орны өнгөц мэт урт нарийн ширдэг, зарим газар гудас ч гэдэг; *ширмэл журам; эрээн өнгөтэй журам.*

ЖУРАМЛАХ юмны үлгэр байдал, ёс заншлыг дууриах буюу мөрдөн дагаж гүйцэтгэх; *журамлан дагах.*

ЖУРАМЛУУЛАХ журамлахын үйлдүүлэх хэв.

ЖУРАМНАХ журамлах, дууриах мөрдөх.

ЖУРАМНУУЛАХ журамнахын үйлдүүлэх хэв, журамлуулах.

ЖУРАМТ журам бүхий, журамтай; *шудрага журамт нөхөр; журамт явдал;* **журамт саная; ардын журамт цэрэг** (1921 оны ардын хувьсгалыг үүсгэн байгуулахад сайн дурааараа нэгдсэн цэрэг); **журамт эр** (авааль эмийг нас нөхцөснөөс хойш нас эцэслэтэл дахин эхнэр аваагүй эр); **журамт шувуу** (хээрийн га-

луу хос салснаас хойш өөртэй холбохгүй тул ийн нэрлэнэ); **журамт гөрөөс** а м ь т а н (цагаан бараатай адил болоод хар бидэртэй, урт сүүлтэй, амьд юм иддэггүй нэг зүйл амьтан).

ЖУРАМТАЙ журам бүхий, журам сайтай, ёстой, зарчим дэглэмтэй; *журамтай болгох; журамтай байцгаа!.*

ЖУРАМТАН журам сайн сахигчид; *шударга журамтан цөөнгүй бий болжээ.*

ЖУРАМШИХ журамтай болох, журамлан занших; *манайхан нилээд журамшиж байна; одоо журамшихгүй бол хэдийд журамших вэ?*

ЖУРАМШУУЛАХ журамшихын үйлдүүлэх хэв.

ЖУУЗ 1. хүн сууж явах дамнуурган сүйх; 2. хоёр хүний туухайчлан барилцсан хоёр гар.

ЖУУЗЛАХ 1. жуузад сууж явах; *жуузалж явах;* 2. гараараа жууз хийх; *гараараа жуузлах;* 3. хүнийг гар жууз дээр суулгах; *жуузлаад яваарай.*

ЖУУЗЛУУЛАХ 1. жуузлахын үйлдүүлэх хэв; 2. жуузлагдах.

ЖУУЛГА I а м ь т а н навчаар хооллон амьдардаг цох; ой модонд хортой, авгалдай нь модны үндсийг иддэг бөгөөд 4—5 жилд амьд байдаг.

ЖУУЛГА II амь, аж; *амь жуулга;* **аж жуулга** х о р ш..

ЖУУЛЧИН орон газар хэрэн хэсч аялан явагч хүн; *европын жуулчин; оросын жуулчин.*

ЖУУЛЧЛАЛ жуулчлах үйлийн нэр, жуулчлах аялал; *жуулчлалаар явах; жуулчлал хийх.*

ЖУУЛЧЛАХ орон газар хэрэн хэсч аялан явах; *гадаад орнуудаар жуулчлах; далайгаар жуулчлах.*

ЖУУЛЧЛУУЛАХ жуулчлахын үйлдүүлэх хэв.

ЖУУМАЙЛГАХ жуумайхын үйлдүүлэх хэв, жуумгар болгох.

ЖУУМАЙХ жуумгар болох; *уруул нь жуумайсан хүүхэд.*

ЖУУМАЛЗАХ инээмсэглэх байдал гаргах.

ЖУУМГАНАХ инээмсэглэх байдал илрэх.

ЖУУМГАНУУЛАХ жуумганахын үйлдүүлэх хэв.

ЖУУМГАР хүний уруул ам үл мэдэг жөмбөгөр; *жуумгар уруултай.*

ЖУУХ: жуух бичиг 1. улс төрд хүчин зүтгэж амжилт гаргасан хүнд дээд газраас олгох сайшаалын бичиг; *засгийн газрын жуух бичиг;* 2. ямар нэгэн төлөөний хүмүүст олгох итгэмжлэл, үнэмших бичиг; *жуух бичиг олгох;* **итгэмжлэх жуух бичиг** (харь улсад улсаа төлөөлөн суулгах дипломат төлөөлөгчид олгох бүрэн эрхийн бичиг); 3. х у у ч и р с а н үе улиран залгамжлах түшмэл албаны хүмүүст олгох үнэмлэх бичиг.

ЖУУЧИН: жуучин хадаас хоёр үзүүр шуумгай, дундуураа бүдүүн нэгэн зүйл хадаас.

ЖҮЖИГ тайзан дээр тоглоход зориулан ярианы хэлбэрээр бичсэн зохиолыг журамлан дагаж наадах тоглолт; **ший жүжиг, жүжиг бүжиг** х о р ш.; *жүжиг тоглох; жүжиг гаргах; жүжгийн зохиол; жүжиг зохиогч; жүжгийн зохиолч; жүжиг найруулагч;* **жүжгийн хэргээ** (жүжгийн анги); **эмгэнэлт жүжиг** (хувийн болон нийгэмлэгийн сонирхлын үүднээс хүмүүс тэмцэлдсээр эцэстээ гол зүйл нь харамсалтай эмгэнэлтэйгээр төгсөх байдлыг дүрслэн үзүүлсэн жүжиг); **инээдэмт жүжиг** (нийгэмлэгийн болон аж амьдралын эгзэгтэй үйл явдлыг инээдэмтэйгээр хошигнон дүрслэн үзүүлсэн жүжиг); **дуулалт жүжиг** (тоглогчид нь найрал хөгжмийн аялгуунд дуулах жүжиг).

ЖҮЖИГЛҮҮЛЭХ жүжиглэхийн үйлдүүлэх хэв, жүжиг тоглуулах.

ЖҮЖИГЛЭХ жүжиг гарган наадах.

ЖҮЖИГЧ (ИН) жүжигт тоглогч; *театрын жүжигч; сайн дурын жүжигч;* **ардын жүжигчин** (гарамгай жүжигчдэд олгох цол).

ЖҮЛЧГЭР бусдад хөнгөмсөг биш, ихээр зантай, ураг удамд элэгсэггүй хөшүүн хүн.

ЖҮЛЧИГНЭХ нүүр бөхтэй байдал илрэх.

ЖҮЛЧИЙХ жүлчгэр болох.

ЖҮЛЧИЛЗЭХ нүүр бөхтэй байдал гаргах.

ЖҮН I 1. төмөр гууль зэргээр ган хувийн шиг том хийсэн, дээрээ өлгөдөг сэнжтэй хонх мэт хөгжмийн зэвсэг, дэлдэж хөгжимдөнө, алтан хөөрөг ч гэдэг; 2. уриа дохионы том хонх; *жүнгийн дуугаар цугларав.*

ЖҮН II хананд өлгөдөг том цаг.

ЖҮНЗ эрхийвчин хундага; *архины жүнз.*

ЖҮНС тогоруу шувууны өөр нэр.

ЖҮНХРЭГ жүн хөгжим.

ЖҮРЖ ургамал өмнөд Азид ургадаг, үргэлж ногоон байдаг жимст модны жимс, төрөл зүйл олон; **алтан жүрж** ургамал (амтат жүржээс жижигхэн, маш амттай, улбар шар арьстай нэг зүйл жимс); **амтат жүрж** ургамал (хэд хэдэн хэлтэс хавсран ургадаг, улбар шар арьстай, амт амтайхан болоод хүчтэйхэн нэг зүйл жимс); **бэрсүүт жүрж** ургамал (амтат жүржээс том, зузаан арьстай, түүхийдээ хүчтэй амттай, хяруу унасан хойно боловсордог нэгэн зүйл жимс); **хүчит жүрж** ургамал (иш модонд сондуутай, жүржимсгээс илүү амттай, жихүүн хяруу унасны дараа боловсордог, арьсы нь балд дарж иддэг нэгэн зүйл жимс).

ЖҮРЖИМСЭГ жүржлэгтэй адил болоод амт муухан, дотор нь хөөвөр хөөхөр байдалтай нэгэн зүйл жимс.

ЖҮРЖЛЭГ ургамал янз хүчит жүржтэй адил болоод зузаан арьстай, амт амтайхан нэгэн зүйл жимс, зарим том нь нэг тохой орчим бий.

ЖҮРҮР нэг зүйл долоогонын үр, эмнэлэгт хэрэглэнэ.

З

З монголын цагаан толгойн үсэг, з үсэг; з авиа.

ЗАА I бусдын хэлсэн хийсэн зүйлийг дагах зөвшөөрөхөд хэрэглэх аялга; *заа, заа яах вэ; заа боль!; заа болно; заа мэдэв;* **заа заа** (а. бусдын хэлсэн тушаасныг лавтайяа хүлээн дагахад хэрэглэх аялга; *заа заа чингэе; заа заа зөвшөөрөв; заа, заа;* б. бусдын хэлснийг үл ойшооход хэлэх аялга; *заа болиоч; заа яршиг даа*).

ЗАА II сул үг, утга илэрхийлэх үгийн өмнө хэрэглэнэ; *заа би явлаа; заа чи сууж бай!; заа олон үг бүү хэл!; заа эс хэл л үү; заа гэвэл ёогүй.*

ЗААВАЛ 1. албан журмаар, дур биш, тушаал, зайлшгүй; *заавал сургах ;заавал нийлүүлэх; заавал гүйцэтгэх; заавал эмчлэх;* 2. эрхбиш, магад, лавтайяа; *заавал ирээрэй; заавал уулзана; заавал мэднэ; заавал өгнө.*

ЗААВАР дагаж мөрдөх, журамлах юм; *ажлын заавар; тогтоол заавар; дүрэм заавар; заавар тушаал.*

ЗААВАРЛАГЧ заавар зөвлөлгөө өгөх албан тушаалын хүн; *намын хорооны зааварлагч.*

ЗААВАРЛАХ заах, заавар өгөх; *зохион зааварлах хэлтэс* (заавар зөвлөлгөө өгөх хэлтэс).

ЗААВАРЛУУЛАХ зааварлахын үйлдүүлэх хэв.

ЗААВАРЧ заах дуртай.

ЗААГ хоёр юмны зах уулзар нийлсэн газар; *нүгийн зааг; хот хөдөөгийн зааг; хилийн зааг;* 2. юмны ялгавар; хуваарь; *ажлын зааг.*

ЗААГГҮЙ зааг, хувиар, заадас байхгүй; *зааггүй ажил; замбараагүй болохын шинж.*

ЗААГГҮЙДЭХ хэтэрхий зааггүй болох; *ажлыг зааггүйдүүлэн хавтгайруулж болохгүй.*

ЗААГДАХ заахын үйлдэгдэх хэв; *ял заагдах; ажилд заагдах.*

ЗААГЛАХ заагтай болгох, зааг тогтоох; *нутаг зааглах.*

ЗААГЛУУЛАХ 1. зааглахын үйлдүүлэх хэв; 2. зааглагдах.

ЗААГТАЙ зааг, хувиар, ялгаа бүхий; *заагтай хэргээс зайцаж болдог.*

ЗААГЧ заах юм, заагч хүн; *заагч зүү; цагны заагч.*

ЗААДАЛ хоёр юмны уулзварыг нийлүүлэхэд харилцан салаавчлан бие биедээ тээглэж бэхлэгдэх тээглүүр; *заадал нийлүүлэх; заадлаараа салах;* **заадал гаргах** (заадаллах); ☆ **тэнгэрийн заадал** (тэнгэрийн оёдол буюу сүүн зам).

ЗААДАЛЛАХ хоёр юмны уулзварыг нийлүүлэхэд харилцан бие биедээ тээглэх тээглүүр гаргах.

ЗААДАС юмны заадлаар уулзар зааг нийлсэн газар; *толгойн заадас; авдарны заадас; заадсаараа салах.*

ЗААДАСЛАХ юманд заадал гаргах, заадаллах.

ЗААДАСЛУУЛАХ заадаслахын үйлдүүлэх хэв, заадаллуулах.

ЗААДУУР хэрчих багаж; нэг талдаа иртэй бөгөөд өргөн, ишээс нь нэг гараар барьж юм

хэрчинэ; *махны заадуур; өвсний заадуур.*

ЗААДУУРДАХ юмыг заадуураар жижиглэн хэрчих.

ЗААЗ бусаддаа үл хүрэх шаар муу юм; *зааз мал; зааз хүн; зааз эд.*

ЗААЗЛАГДАХ заазлахын үйлдэгдэх хэв; муу буюу шаарын учир ялгагдах.

ЗААЗЛАХ юмны шаар, муугий нь ялгах; *хонь малыг заазалж ялгах.*

ЗААЗЛУУЛАХ 1. заазлахын үйлдүүлэх хэв; 2. заазлагдах.

ЗААЗУУР заадуур.

ЗААЗУУРДАХ заадуурдах.

ЗААЗУУРДУУЛАХ заазуурдахын үйлдүүлэх хэв.

ЗААЛГАХ 1. заах I, II, III-ын үйлдүүлэх хэв; *хичээл заалгах; эрүү заалгах; банз мод заалгах;* 2. заагдах; *ял заалгах.*

ЗААЛГУУЛАХ заалгахын үйлдүүлэх хэв.

ЗААЛДАГЧ заалдсан этгээд; *заалдагч хүний хэлэх нь... .*

ЗААЛДАХ тэмцэн заргалдах; *амаар заалдах; бичгээр заалдах; давж заалдах.*

ЗААЛДЛАГА заалдах үйлийн нэр, зарга заалихай хийх.

ЗААЛДУУЛАХ заалдахын үйлдүүлэх хэв.

ЗААЛТ заах үйлийн нэр; *заалтын чанар муу; оновчтой заалт хийх.*

ЗААЛХАЙ зарга, тэмцэл; **зарга заалхай** хорш.. .

ЗААЛХИЙЛЭХ 1. заах зааварлах; *сурган заалхийлэх; ухуулан заалхийлэх;* 2. байн байн заах; дахин дахин заах; 3. цохлон заах; *томилон заалхийлэхийг хүснэ.*

ЗААМ дээл хувцасны энгэр харааны уулзар, хоолойн товч торгох газраас доош хэсэг газар; **зах заам, энгэр заам** хорш.; *заамыг сэтлэх; заамаа ярах.*

ЗААМАЛ зааж хийсэн юм; *заамал дүнзэн байшин.*

ЗААМДАХ заамны тус газраас барьж үгээх; *заамдаж аваад жанчив гэнэ.*

ЗААМДУУЛАХ 1. заамдахын үйлдүүлэх хэв; 2. заамдагдах.

ЗААН 1. хушуутны язгуурын сүүн тэжээлт амьтан; урт хушуутай, хоёр том соёотой, дундад Африк ба Энэтхэгт байдаг; *зааны соёо; зааны яс; зааны сүү;* **заан мод** ургамал (асар том нэг зүйл шилмүүст мод. зарим газар зэрлэг ургана, зарим газар тарьж ургуулна); **заан таваг** ургамал (хужир боргио, булаг, намаг гүн элс бүхий газраас бусад газарт ургана; хүрэн судалтай ногоон иштэй, хүний хумсын төдий дүгрэг бөгөөд догол гарсан захтай, боровтор, ногоон навчтай, жижиг цагаан цэцэгтэй, үр таван хэлтэс нийлсэн, шивээ өргөстэй нэгэн зүйл ургамал); 2. монгол бөхийн барилдах наадам тэмцээнд долоо буюу найм давсан бөхөд олгох цол; *зааныг хаяж заан болно.*

ЗААР 1. хүдрийн хүйсэн дэх ханхалж анхилсан үнэртэй бөм; *хөлөрсөн хөлсий чинь үнэрлэвэл хүдрийн заарнаас юуны өөр вэ (ардын дуу);* 2. шинхэг, хатан үнэр; *ухны заар; тарваганы заар;* 3. хатан үнэртэй булчирхай; *заар булчирхай.*

ЗААРАГ газар малтахад тохиолдох хад чулуу мэтийн хатуу үе.

ЗААРАХ эрүүний углуурга шинэж өвдөх буюу мултрах; *эрүү заарах.*

ЗААРМАГ багсарсан гурил.

ЗААРМАГЛАХ гурил багсран бантан мэт болгох.

ЗААРМАГТАХ заармаг байдалтай болох.

ЗААРМАГШИХ заармаг шинжтэй болох.

ЗААРТ заар бүхий юм; *заарт булчирхай;* **заарт мод** ургамал (дулаан оронд ургадаг нэг зүйл мод, үндсий нь шатаахад анхилам сайхан үнэртэй).

ЗААРЦАГ I загасны сүрэг; *загасны заарцаг.*

ЗААРЦАГ II амьтны үлэмж олноор бөөгнөрөн цугларсан нь; *ялаа батганы заарцаг; хорхой шавьжийн заарцаг; театрын үүдэнд хүн гэдэг заарцаг харагдана.*

ЗААРЦАГЛАХ амьтны олноороо цуглаж заарцаг болох.

ЗААРЬ I агталсан цаа.

ЗААРЬ II хүдрийн заар.

ЗААХ I 1. бусдад юмны учир чанарыг сургаж зааж мэдрүүлэх; *бичиг заах; хичээл заах; зүг чиг заах;* 2. ямар нэгэн юмаар бусдын зүг зангах, дохиолох, цохлох; *хуруугаар заах; үзгээр чичлэн заах; цохлон заах;* **заах хуруу** (долоовор хуруу); **буурь заах, хана заах** (амьтны хашир догь байдал гаргах); **булчин заах, шөрмөс заах, шил заах** (чадал тамиртаа эрдэж тэсвэрлэх); **зүрх заах, зориг заах** (эрэмгий шийдэмгий байдал гаргах); **өмч заах, хувь заах** (өөрийн нь мэдлийн болгож хөрөнгө юм таниулж эзэмшүүлэх); **чадал заах, чийр заах** (а. хүч тамиртаа эрдэх; б.

хөрөнгө чинээндээ эрдэх); **яс заах** (а. зөрүүд хөгжүүн байдал гаргах; б. дүжир тэсвэртэй байх; *сайн морь гэсэндээ яс заааж байна; чанар сайтай эд учир яс заааж байна);* **ял заах** (гэмтэнд шийтгэл зэмлэл оногдуулах); **заах арга** (бусдад юм зааж сургахад хэрэглэх хэлбэр); **заахын тийн ялгал** (монгол хэлний «хэнийг, юуг» гэсэн асуултад хариулагдах тийн ялгал); **заах төлөөний үг** (төлөөний үгийн нэг зүйл).

ЗААХ II юмыг ангилан салгах; **эрүү заах** (мал гөрөөсний толгойг эрүүний завсраар ярж татан салгах).

ЗААХ III юманд заадал, заадас гаргах; *цонхны яс мод заах.*

ЗАВ I чөлөө зай; **зав чөлөө, зай зав** х о р ш . ; *зав болбол орой ирнэ.*

ЗАВ II уулын завсар хоорондын гүн явцуу газар; *уулын зав.*

ЗАВААДАХ хэтэрхий заваан болох, завааны учир тохиромжгүй болох.

ЗАВААН 1. хоол хүнсний тос нүмжиггүй буюу амт шимт муутай; *заваан хоол; заваан будаа;* 2. хүн амьтны дэндүү болхи бүдүүлэг буюу будлиу байдалтай; *заваан ажиллагаатай хүн; заваан хөдөлж байна;* 3. жигшмээр, зэвүүцмээр байдалтай; *заваан хүн; заваан айл;* **заваан үг** (шимгүй буюу ичгүүрэлтэй бүдүүлэг үг яриа); **заваан ажил** (бүтэл муутай, урагш муутай ажил); **заваан дургана** у р г а м а л (навч нь ялма модны навчтай адил болоод баахан нимгэн, цэцэгтэй нэг зүйл мод); **заваан өлөн** у р г а м а л (үет цагаан хулс бүхий хотгор газарт хольцолдон ургах нэг зүйл өвс).

ЗАВААНДУУ арай заваан, баахан заваан.

ЗАВААРАХ заваан болох; **ам заваарах** (ам хуурайших); **шүлс заваарах** (шүлс өтгөрөх); **ажил заваарах** (үйл ажил бүтэхгүй унжрах, будлих); **бие заваарах** (хэтэрхий залхуу хүрэх).

ЗАВААРУУЛАХ заваарахын үйлдүүлэх хэв, заваан болгох.

ЗАВАГ туурганы хоолой цаваг хоёрын завсар; *залхуу эмгэн завагтаа хүрэхгүй з у й р .*

ЗАВГҮЙ зав чөлөө олдохгүй, завсар чөлөө гарахгүй.

ЗАВДАА 1. гүйцэтгэх бүтээх чөлөө завсар, зай, зав; **чөлөө завдаа, зай завдаа** х о р ш . ; 2. самбаа, авхаалж, шаламгай ажиллагаа; *завдаа сайтай; завдаа муутай.*

ЗАВДААГҮЙ 1. самбаа авхаалжгүй; *завдаагүй хүнд зав гардаггүй;* 2. амжил болоогүй; *хийх гэсэн болович завдаагүй л байна.*

ЗАВДААТАЙ түргэн гавшгай, самбаатай, зай чөлөөг ашиглахдаа сайн; *завдаатай хүнд завсар чөлөө мундахгүй.*

ЗАВДАЛ завдах үйлийн нэр, зав, зай; *завдал гаргая; завдлаа харж байж болъё.*

ЗАВДАМГАЙ гавшгай завдлагатай.

ЗАВДАХ I үйлдэж амжих, амжуулах, өрсөх, урьтах; **амжих завдах** х о р ш . ; *би маргааш явахынхаа өмнө ажлаа гүйцээж завдана; хоёр цаг болтол завдаж сургууль дээр очъё; би явахын урьд энэ номыг уншиж завдлаа; түргэн завдвал галт тэрэг хөдлөхөөс өмнө хүрнэ.*

ЗАВДАХ II үйлдэхэд хүрэх, дөхөх, тулгарах; *явахыг завдах; бичихийг завдтал; гэмт хэрэг хийхийг завдах; харахыг завдах; авахыг завдах; эхлэн завдмагц ....*

ЗАВДЛАГА завдах үйлийн нэр; *завдлага сайтай; завдлага муутай.*

ЗАВДУУЛАХ завдахын үйлдүүлэх хэв.

ЗАВИЛАЛ завилгаа.

ЗАВИЛАХ хоёр өвдөг нугалж, хөл өлмий зөрүүлдэн суух; *лаахайтлаа завилсан сүрхий амьтан байна; завилж суух.*

ЗАВИЛГАА 1. завилах үйлийн нэр; *завилгаа ихэдвэл ажил чинь удааширна;* 2. зарим нэг юмыг завилсан мэт байдлаар боосон боодол; *завилгаатай нь эм; завилгаагүй нь тан.*

ЗАВИЛГАХ 1. завилуулах, завилахад, хүрүүлэх; 2. зарим юмыг завилах маягаар боох, боодоллох; *эм тан завилгаж боох.*

ЗАВИЛУУЛАХ завилахын үйлдүүлэх хэв, завилгах.

ЗАВОД 1. **түүхий** эдийг боловсруулах үйлдвэрийн газар; *сүүний завод; тосны завод; арьс ширний завод;* 2. сайн үүлдрийн мал өсгөх аж ахуй; *морин завод.*

ЗАВСАР 1. цаг хугацааны хоорондын зай зааг; *өдөр шөнийн завсар; хавар зуны завсар; завсар чөлөө;* 2. юмны уулзар нийлэлт буюу зай чөлөө; *арьс махны завсар; хумсны завсар; завсар заалхай эрэх; зай завсар;* 3. хоёр юм-

ны хооронд; *тэнгэр газрын завсар; чи бид хоёрын завсар; хурууны завсар; хол ойрын завсар;* **завсрын үүл** (улаан үүл).

ЗАВСАРГҮЙ 1. юмны хооронд зай сувгүй; *завсаргүй чигжих; завсаргүй наах;* 2. зогсоо чөлөөгүй; *завсаргүй ажиллах; завсаргүй тоглох;* 3. маш дотно нөхөрлөх; *завсаргүй янаг; завсаргүй ханилах.*

ЗАВСАРДАХ 1. алинд ч үгүй хийдэх, хоцрох; *ажил завсардах; захиргаа завсардах;* 2. хоорондоо холдох, харилцан муудах; *харилцаа холбоо завсардах; нөхөрлөл завсардах.*

ЗАВСАРДМАЛ завсардсан нь.

ЗАВСАРДУУЛАГЧ завсардуулах этгээд.

ЗАВСАРДУУЛАХ завсардахын үйлдүүлэх хэв.

ЗАВСАРЛАГА завсарлах үйлийн нэр; завсар, чөлөө, *үдийн завсарлага; хичээлийн завсарлагаар кино үзэх; хурлын завсарлагыг хүлээж байгаад уулзав.*

ЗАВСАРЛАХ 1. ямар нэгэн юмны ажиллагаа түр зогсохийх, завсар гаргах; *хичээл завсарлах; хурал завсарлах; ажил завсарлах;* 2. юмны хөдөлгөөн түр зогсох, сэгхийх; *салхи завсарлах; бороо завсарлах.*

ЗАВСАРЛУУЛАХ завсарлахын үйлдүүлэх хэв, завсартай болгох.

ЗАВСАРТАЙ юмны хооронд зай чөлөөтэй болох буюу завсар гаргах; *завсартай үйлдэх;* **завсартай үзэх** (ялгаатай үзэх); **загасны мах завсартай** (хүний өөрийн хоёр ялгаатай).

ЗАВСАРТАХ завсар гаргах, завсартай болох; *завсартан харагдав.*

ЗАВСАРЧЛАХ 1. үйл ажил хийх бүтээхэд завсар чөлөө хайх эрэх; *зай самбаа эрж завсарчлан явах;* 2. юмыг завсартайгаар үзэх; *нэгийг дотнолон нөгөөг гадуурхан завсарчлах.*

ЗАВТАЙ зав бий, зайтай, чөлөөтэй; *би өнөөдөр үдээс хойш завтай; маргааш бол хэдийд ч завтай.*

ЗАВТАЙХАН арай завтай, баахан завтай.

ЗАВХАЙ I ааль явдал самуун зальхай; *завхай хүн; завхай биттий яваарай!;* **завхай зайдан** (завхай хөнгөн).

ЗАВХАЙ II даалуу наадмын дүрс өөр боловч нүхний тоо адил хошоодоор хослох мод; *есийн завхай; дөнгө найм, муруй наймын завхай; хөзрийн завхай.*

ЗАВХАЙДАХ хэтэрхий завхай болох.

ЗАВХАЙРАХ I садар самуун явдал үйлдэх.

ЗАВХАЙРАХ II завхай II-ын хос хосоор нийлэх; *над дөрвөн ес завхайрч ирэв.*

ЗАВХАЙРУУЛАХ завхайрахын үйлдүүлэх хэв.

ЗАВХАХ 1. ямар нэгэн юм санамсаргүй алга болох, алдагдах; *миний морь завхаж үгүй болов;* 2. юмны сураг чимээ тасран, сонсдож мэдэгдэхээ болих; *өнөөх худал яриа чинь завхсан шиг байна;* 3. завхрах.

ЗАВХРАЛ завхрах үйлийн нэр; *ажлын завхрал; алдаа завхрал; завхрал гаргах.*

ЗАВХРАХ 1. хүний ажил явдал буруудан сөргүү гажуу болох; *ажил завхрах; завхарсан хүн;* 2. үүл, утаа, манан арилж сарних; *үүл завхрах;* 3. эд мал зэрэг юмны алдагдаж үгүй болох; *мал завхрах; эд завхрах;* 4. сарних, хулжих; *нойр завхрах;* 5. завхайрах.

ЗАВХРУУЛАГЧ завхрал гаргагч.

ЗАВХРУУЛАХ завхрахын үйлдүүлэх хэв.

ЗАВХУУЛ 1. алдуул; *завхуул мал барих; завхуул эд авах;* 2. захиргаагүй, өөрийн гэх газаргүй; *завхуул хүн; завхуул этгээд.*

ЗАВХУУЛАХ завхахын үйлдүүлэх хэв.

ЗАВЧЛАХ аливаа үйл үйлдвэрийг зав чөлөө гарган үйлдэх, зав завтаа хийх.

ЗАВШААН жавшаан.

ЗАВШААХ жавшаах.

ЗАВШААЧ жавшаач.

ЗАВШИГЧ завшдаг этгээд, жавшигч.

ЗАВШИГДАХ завшихын үйлдэгдэх хэв, завшуулах.

ЗАВШИЛ жавшил.

ЗАВШИХ жавших.

ЗАВШУУЛАХ завшихын үйлдүүлэх хэв, жавшуулах.

ЗАВЬ усанд явахад хэрэглэдэг жижигхэн гар онгоц; **шумбадаг завь** (цэргийн хөлөг онгоц, усан дээгүүр доогуур явж чадна).

ЗАВЬЖ 1. хүн амьтны амны хоёр сэжүүр; 2. уулын ам хөндийн хоёр хажуугийн газар.

ЗАВЬЯА I цай хийх өндөр хүзүүтэй сав; *мөнгөн завьяа; гуулин завьяа.*

ЗАВЬЯА II нэгэн зүйл үндсэрхэг ширхэгтэй мод; чанар хөнгөн; *завьяа аяга.*

ЗАГ I у р г а м а л говь газарт ургадаг дурс цагаан, ширхэг артай, яслаг хатуу, юм хийхэд тохиромжгүй, найлзуур нь шилмүүсийн хэлбэртэй, замбага хэлбэртэй туурцгийн дотоодод цагираг ногоон үртэй нэгэн зүйл мод; их төлөв элсэрхэг хөрстэй хонхор тойромд ихээхэн хужирлаг газар ургана.

ЗАГ II хүний бэлгийн эрхтнээс гарах идээр; **заг хүйтэн** (хүний бэлэг эрхтнээс идээр гарах хүйтэн өвчин).

ЗАГАА хувцасны зах хөвөөний чимхээр.

ЗАГААДАХ хувцсанд загаа хийх.

ЗАГАГ гуалин модыг зөрүүлдэн нүхэлж хөшүүр хэлхэн хийсэн шүргэн шивээ.

ЗАГАЛ малын зүсмийн нэр, цагаанд өөр өнгө баахан холилдсон нь; *улаан загал; бор загал; цагаан загал.*

ЗАГАЛАЙ а м ь т а н янз бүргэд адил, бие бараан, сүүл охор, өдөнд өчүүхэн төдий бараан шивээ бий, сүүл цагаан ч бас бий.

ЗАГАЛАХ загатнах, гүвэгнэх.

ЗАГАЛМАЙ I тооноложин буюу хэрээс тэмдэг; **улаан загалмай нийгэмлэг** (дайны цагт өвчтэй, шархтай цэргүүдэд эмнэлгийн тусламж үзүүлэх; тайван цагт гэнэтийн аюулд автагдсан хүнд туслах үүрэгтэй сайн дурын байгууллага, цагаан артай юман дээр хийсэн улаан загалмай тэмдэгтэй); **загалмай бялзуухай а м ь т а н** (нэгэн зүйл бялзуухай, гох хушуутай, эрэгчний эрүү солгойгор солбин, эмэгчний эрүү баруунаар солбисон байдаг, шилмүүст модны навч идэж амьдарна).

ЗАГАЛМАЙ II нүхт хөгжмийн зэвсгийн нүхний амсрыг товшрон дуугаргах нимгэн төмөрлөг хэл.

ЗАГАЛМАЙДАХ юмыг загалмай хэлбэртэй болгох.

ЗАГАЛМАЙДУУЛАХ загалмайдахын үйлдүүлэх хэв.

ЗАГАЛМАЙЛАХ 1. загалмай болгох; 2. христос шашинд оруулан авах зан үйл үйлдэх.

ЗАГАЛМАЙЛЖИН загалмай хэлбэртэй.

ЗАГАЛМАЙЛУУЛАХ загалмайлахын үйлдүүлэх хэв.

ЗАГАЛМАЙТ загалмайтай.

ЗАГАЛМАЙТАН загалмайн шашинтан; **загалмайтны аян дайн** (баруун европын феодалуудаас 1096—1270 онд хийсэн аян дайн).

ЗАГАС (АН) I загалмайгаар амьсгалдаг, хүйтэн цустай, хайрсан арьстай, усанд оршдог, сээр нуруутай амьтны ерөнхий нэр; бүгд нэг түмэн зүйлээс гол нуурт орших нь хоёр мянга таван зуу, бусад нь далайд оршино, заримд нь цахилгаан ба гэрэл үүсгэх эрхтэн бий; *загас барих; загас үржүүлэх, загасны тос; загасны дэгээ;* **загас харвах сэрээ** (төмрөөр таван салаатай сэрвээ гаргаж хийгээд, харвахад тохируулан өд өдөлсөн нэгэн зүйл сэрээ); **загасны залмагай** (загасны зажуурын ясны дотоодод зэрэг зэрэг ургасан улааныг); **загасны далбаа** (загасны өехийд жигүүрийн адил ургасан хойтох том сэлбүүр); **загасны хайрс** (загасны нуруунд байдаг аржгар артай зүйл); **загасны түрс** (загасны үр саг); **загасны сүүл** (онгоцыг хөндөн сэлж явуулах загасны сүүл хэлбэртэй зэвсэг); **загасны цавуу** (загаснаас авах нэгэн зүйл цавуу, юм наахад сайн); **загасан талх** (зуувгар бөгөөд загас маягийн хэлбэртэй талх); **загасан нуруу хатгах** (нэгэн зүйл оёдол, түүнийг хатгасан утасны байдал нь загасны нуруутай төсөөтэй); **загасан нуруу орхих** (гутал шааврын зэрэг юманд зүүгээр утсыг сүлжин торгох).

ЗАГАС II: **загасан од з у р х а й** Молын хойтох тэнгэрийн оёдолд байх одны нэр.

ЗАГАСЧ (ИН) загас гөрөөчилдөг хүн.

ЗАГАСЧЛАХ загас гөрөөлөх.

ЗАГАСЧЛУУЛАХ загасчлахын үйлдүүлэх хэв.

ЗАГАТНАА загатнах үйлийн нэр, арьс махнаа жирвэгнэх нь мэдрэгдэхүй.

ЗАГАТНАХ хүн амьтны биед өвчин ба хорхойн хор зэргээс арьс мах жирвэгнэх гүвэгнэх мэтээр тачаадуулах; *бие загатнах; толгой загатнах.*

ЗАГАТНУУЛАХ загатнахын үйлдүүлэх хэв, загатнахад хүргүүлэх.

ЗАГАТНУУР нэгэн зүйл **загатнах** өвчин.

ЗАГАЧЛАХ загасчлах.

ЗАГВАР 1. юмны байдлыг үзүүлсэн үлгэр; *байшингийн загвар; малгайн загвар;* **үлгэр загвар** х о р ш.; 2. байдал төлөв, дүр дүрс; *загварыг ажиглах;* 3. хэв хэлбэр; *загвар сайтай; загвар муутай.*

ЗАГВАРДАХ 1. загварыг дууриах; 2. байдал төлөвийг зориуд **анхааран ажиглах.**

ЗАГВАРДУУЛАХ загвардахын үйлдүүлэх хэв.

ЗАГВАРЛАХ загвар болгох, загварлах.

ЗАГВАРЛУУЛАХ загварлахын үйлдүүлэх хэв.

ЗАГЗАЙЛГАХ загзайхын үйлдүүлэх хэв.

ЗАГЗАЙХ загзгар юмны байх байдал, загзгар болох.

ЗАГЗАЛЗАХ загзгар юмны байн байн хөдлөх байдал.

ЗАГЗГАНАХ загзгар юмны үргэлжлэн хөдлөх байдал.

ЗАГЗГАР хүн амьтны бие пагжгар буюу үс сахлаг арзгар.

ЗАГИНАХ загнах, зандрах; хүүхэд загинах.

ЗАГИНУУЛАХ загинахын үйлдүүлэх хэв, загнуулах, зандруулах.

ЗАГЛАГАР загзгар сагсгар юм.

ЗАГЛАЙЛГАХ заглайхын үйлдүүлэх хэв, заглайхад хүргүүлэх.

ЗАГЛАЙХ заглагар болох, заглагар юмны байгаа байдал.

ЗАГЛАХ хүний бэлэг эрхтнээс заг гарах.

ЗАГЛУУН идэх юм зажлахад маш дөжир хатуу.

ЗАГНАХ I аашлах, зандрах; *аашилж загнаад юугаа хийх вэ.*

ЗАГНАХ II зан тавих; *гутал загнах.*

ЗАГНУУЛАХ 1. загнахын үйлдүүлэх хэв; 2. гуталд зан тавиулах.

ЗАГСААЛ у р г а м а л хад чулуу бүхий хяр дэнж ба хахир хатуухан газарт бутлан ургана, навч жижиг ногоон өнгөтэй, гадууpаа бор хальс бүхий иштэй.

ЗАГСААХ загсахын үйлдүүлэх хэв, загсахад хүргүүлэх; *өрөм загсаах.*

ЗАГСАХ 1. амуу тарианы зэрэг юмны чанагдаж өтгөн аглиун болох; *будаа загсах;* 2. халуун юмны хөрч царцанги болох; *тогоотой суу загсах; тос загсах.*

ЗАГТАХ заг хүйтэн өвчин хүрэх, хүйтэнтэх.

ЗАГТУУЛАХ загтахын үйлдүүлэх хэв, хүйтэнтүүлэх.

ЗАГЬСАХ малын төлийг өөрийн эх нь цатгахгүйд өөр эхэд хөхүүлэх буюу өөрөө өөр малыг хулууж хөхөх; *тугал загьсах.*

ЗАГЬСУУЛАХ 1. загьсахын үйлдүүлэх хэв; 2. загьсагдах; *үнээ загьсуулах.*

ЗАД I бороо хур орох зэргээр тэнгэрийн байдал гэнэт хувирах үзэгдэл; **шувууны зад** (шувуу буцах үеэр орох хур бороо); **задын чулуу** (шинэ чулуун зэвсгийн үлдэц); **зад өвс** у р г а м а л (уул хээрт ургах өвс, төрөл зүйл олон, эртнээс нааш хүн амьтны яс махны шарх гэмтлийг анагаах чадалтай гэж авч хэрэглэсээр иржээ).

ЗАД II тухайн үйлийн эрс хүчтэйг үзүүлэн дайж орох үг; *зад татах; зад цохих; зад мушгих; зад угаах.*

ЗАДАРГАХ задрахад хүргүүлэх.

ЗАДАРХАЙ 1. задарсан, хагархай; *задархай авдар; задархай сав; задархай зуух;* 2. задгай; *задархай амтай хүн.*

ЗАДАРХАЙДАХ задархайн учир тохиромжгүй болох.

ЗАДАРХАЙДУУЛАХ задархайдахын үйлдүүлэх хэв.

ЗАДАРХАЙТАХ задархай яриа ярих.

ЗАДГАЙ 1. ямар нэг юмны хаалт хорго бэхлээгүй ил, сул чөлөөтэй, бутархай; *задгай хашаа; гэр задгай; энгэр задгай; задгай ус; хээр задгай билчээр; задгай мөнгө;* ☆ **задгай хатир** (морины чөлөөтэй хатирах явдал); **ам задгай** (юу үзсэн, сонссон, дуулснаа бусдад ярих зантай); 2. юмны цоож бэхлэгээгүй; *гэр задгай; үүд задгай;* 3. зөөлөн буюу ширхэгт юмны эрч сүлжээс буюу эздрээ ороцолдоогүй *задгай ноос; задгай утас;* 4. юмыг нууж хаахыг мэдэхгүй эрээ цээргүй ярих; *задгай амтай хүн;* 5. **аман этгээд нь төлүү буюу таглаагүй** сав; *задгай амтай сав.*

ЗАДГАЙДАХ задгайн учир тохиромжгүй болох.

ЗАДГАЙДУУ арай задгай, баахан задгай.

ЗАДГАЙДУУЛАХ задгайдахын үйлдүүлэх хэв.

ЗАДГАЙЛАХ задгай болгох; *ус задгайлах.*

ЗАДГАЙЛУУЛАХ задгайлахын үйлдүүлэх хэв, задгай болгуулах.

ЗАДГАЙРАХ 1. задгай болох, задрах, уужим тэнүүн болох; 2. эмх замбараагаа алдах, танхайрах; *ажил задгайрав; задгайрсан амьтан;* 3. хүн өтгөн шингэнээ тэвчиж үл чадах; *шээс задгайрах.*

ЗАДГАЙРУУЛАХ задгайрахын үйлдүүлэх хэв.

ЗАДГАЙТАХ задгай байдалд автах.

ЗАДГАЙХАН задгайдуу, арай задгай, баахан задгай.

ЗАДЛАГ ямар нэг юмны чанар, бүтэц зэргийг ялган салгаж тал бүрээс нь судлах шинжилгээний арга; *задлаг арга.*

ЗАДЛАГДАХ задлахын үйлдэгдэх хэв.

ЗАДЛАГЛАХ задлаг аргаар судлан үзэх. *цус задлаглах.*

ЗАДЛАХ задрахад хүргүүлэх, задгай задархай болгох; 1. битүү далд юмыг онгойлгох, тайлах, нээх, ил болгох; *лаазтай сүү задлах; лонхтой архи задлах; авдар хайрцаг задлах; ачаа задлах; ваадан задлах; нууц задлах; үг задлах; хүүр задлах;* 2. цогцлон бүтээсэн, бүтсэн юмыг салгах, эвдэх, цуцлах, сарниулах, бутлах; *олс задлах; гэзэг задлах; ноос задлах; хөвөн задлах; машин задлах; хөрс задлах; аршаан задлах; задлан шинжлэх; тогтоол шийдвэр задлах; нэгдэл задлах; цэргийн хүч задлах; мөнгө задлах.*

ЗАДЛУУЛАХ задлахын үйлдүүлэх хэв, задгай болгуулах.

ЗАДРААХ I задрахад хүргүүлэх; *нууц задраах.*

ЗАДРААХ II задрах II-ын үйлдүүлэх хэв; *тэнгэр задраах.*

ЗАДРАГАА задарсан юм.

ЗАДРАНХАЙ задархай болсон, задарсан нь.

ЗАДРАНХАЙТАХ задархайтах.

ЗАДРАХ I задгай болох; 1. юм цуцран алдрах, тайлдах, битүү далд юм онгойх, илрэх; *боодол задрах; баглаа нь задрах; хүлээс задрах; хошлон задрах; дээс задрах; утас задрах; нууц задрах; мэдээ задрах;* 2. цогцлон бүтсэн, бүтээсэн юм эвдрэх, сарних, бутрах; *авдар сав задрах; араг савар задрах; нүүрс задрах; шийдвэр задрах; хэрэг задрах; хүч задрах; эв нэгдэл задрах; шарх задрах; бэрсүү задрах; бөмбөг задрах;* 3. хэм зүйгээс гадуур хэтрэмгийлэх; *задарсан хүүхэд; тэр дэндүү задарч байна;* 4. ухаан бодол өрнөн нэмэгдэх; *ухаан задрах; мэдлэг задрах; самбаа задрах.*

ЗАДРАХ II: **тэнгэр задрах** агаарт үүл манан бүрхэж салхи шуурга дэгдэн эвгүй болох.

ЗАДРУУЛАГЧ задгай болгогч, илэрхий болгогч; *нууц задруулагч.*

ЗАДРУУЛАХ задрахын үйлдүүлэх хэв.

ЗАДУУЛАЙ амьтан цэндээхийгээс арай их, ногоон өнгөтэй нэгэн зүйл бялзуухай.

ЗАДЧИХ байн байн задлах.

ЗАДЬ ургамал халуун орны анхилам сайхан үнэртэй нэг зүйл модны үр.

ЗАЖИЛБАР идэшний зүйлийн хазахад дожир бөгөөд хялбархан улбас болохгүй нь; *зажилбартай; зажилбаргүй.*

ЗАЖИЛГАА зажлах үйлийн нэр.

ЗАЖЛАХ 1. идэх юмыг шүдээр хазаж няцчих; *бохь зажлах;* 2. хүнийг далдуур бурууштаан хэлэлцэх; *зажилж ярих; зажлалгүй залгих;* 3. хайч зэрэг юмны ир тээглэн, хайчилж байгаа юмаа хэгэх; *хайч зажлах.*

ЗАЖЛУУЛАХ 1. зажлахын үйлдүүлэх хэв; зажлагдах.

ЗАЖУУР хацрын хойтох хэсэгхэн газар; *зажуурын булчин.*

ЗАЗАЙЛГАХ 1. зазгар юмны байгаа байдал; 2. зазайхад хүргүүлэх.

ЗАЗАЙХ зазгар болох.

ЗАЗАЛЗАХ зазгар юмны байн байн хөдлөх байдал.

ЗАЗГА I бог малд тусах нэгэн зүйл сочмог өвчин.

ЗАЗГА II санд мэнд, тэвдүү.

ЗАЗГАДАХ ихэд сандрах, тэвдэх, бачимдах.

ЗАЗГАДУУЛАХ зазгадахын үйлдүүлэх хэв.

ЗАЗГАНАХ зазгар юмны үргэлжлэн хөдлөх байдал.

ЗАЗГАНУУЛАХ зазганахын үйлдүүлэх хэв, сандруулах, тэвдүүлэх, бачимдуулах.

ЗАЗГАР бие бага бөгөөд үс ноос сахлаг юм; зазгар цэцгэр х о р ш.. .

ЗАЗГАТАХ зазга өвчин тусах.

ЗАЙ I 1. ямар нэгэн юмны юм багтаах агуулах завсар, хөндий газар; *гэр барих зай; зураг тавих зай; байшингийн зай;* 2. чөлөө завтай; *зай завгүй ажиллах; зай чөлөөг үзэж уулзах;* 3. завсар хоорондын хэмжээ; *Улаанбаатар Төв аймгийн хооронд 45 км. зай бий; Ховд эндээс их зайтай.*

ЗАЙ II 1. зарим нэгэн язгуур махбод; *цахилгаан зай; химийн нарийн зай;* **зай хураагуур** (аккумулятор); 2. ямар нэгэн юманд зайлшгүй орж хэрэглэгдэх хачир хольц.

ЗАЙ III самбаа, заль, сий; *зайтай хүн шүү, яаж ч мэднэ.*

ЗАЙ IV маш өчүүхэн; *зайн төдий махтай хоол; над боовны зай амсуулав.*

ЗАЙГУУЛ тэнүүл; *зайгуул хүн.*

ЗАЙГҮЙ I 1. багтаамжгүй, багтахгүй; 2. зав чөлөөгүй. 3. завсар байхгүй.

ЗАЙГҮЙ II ний нуугүй, маш дотно; *тэр хоёр хөл зайгүй хүмүүс шүү.*

ЗАЙГҮЙДҮҮЛЭХ зайгүйдэхийн үйлдүүлэх хэв.

ЗАЙГҮЙДЭХ зайгүйн учир зохисгүйдэх.

ЗАЙДАГНАХ морь мал зэргийг зайдан унах.

ЗАЙДАН 1. унах морь малын эмээл тохомгүй нь; *зайдан морь; зайдан тэмээ;* 2. хаваржаа намаржааны нөмөрлөх, халхлах юмгүй өндөрхөн цулгуй газар.

ЗАЙДАНДАХ 1. аливаа юмыг олох зэрэгт олохгүй хоосон болох; 2. завсар зай гарах; *ажил хоорондоо зайдандах;* 3. зайдангийн учир тохиромжгүй болох.

ЗАЙДАНДУУЛАХ зайдандахын үйлдүүлэх хэв.

ЗАЙДАС хонь малын нарийн гэдсийг бүтүүнд цус цутгасан нь; **цус зайдас** х о р ш..

ЗАЙДАХ эхнэр хүний толгойн үсээ шанхлах.

ЗАЙДЛАХ 1. морь малыг эмээл тохомгүйгээр унах; *морь зайдлах;* 2. хүний ямар нэгэн юман дээгүүр мордох; *хүүхэд аавыгаа зайдлах; хашаан дээр зайдлах; мод зайдлах;* 3. морь малын мундааны хойтох газар.

ЗАЙДЛУУЛАХ 1. зайдлахын үйлдүүлэх хэв; 2. зайдлагдах.

ЗАЙДУУ нилээд зайтай; *зайдуу газар орших нэгэн байшинд оров.*

ЗАЙДУУХАН нилээд зайдуу, баахан зайдуу; *голын уснаас зайдуухан буув.*

ЗАЙЛАМТГАЙ юмнаас булгарамхай.

ЗАЙЛАХ I 1. юм сэгсэрхийлэн сажин хөдөлгөх; *хир буртгийг угааж зайлах;* 2. сав суулга мэтэд өөр юм түрхэн тогтоох; *тугалгаар зайлах; тосоор зайлах; эмээр зайлах;* 3. бие ширүүн хөдөлснөөс болж гэдсэнд эмгэг олох; *гэдэс зайлах.*

ЗАЙЛАХ II 1. амьтны байсан газраасаа ангижрах, зугадах; *оргон зайлах; бууруулан зайлах;* 2. хойш сууж хойргоших; *ажлаас зайлах; хариуцлагаас зайлах;* 3. аюул хөнөөлөөс хэлтрэх; *үхлээс зайлах; өвчнөөс зайлах.*

ЗАЙЛГАХ зайлагдах ба зайлах зайхад хүргүүлэх.

ЗАЙЛСХИЙХ аливаа үйл явдлаас зугадах, хойш суух; *биеийн хөдөлмөрөөс зайлсхийх.*

ЗАЙЛУУЛ өрөвдөн хайрлахад гарах аялга; *хөөрхий зайлуул, тэгээ юу!*

ЗАЙЛУУЛАХ I зайлах I-ийн үйлдүүлэх хэв; *тогоо зайлуулах.*

ЗАЙЛУУЛАХ II зайлах II-ын үйлдүүлэх хэв; *ажлаас зайлуулах; биеэ зайлуулах.*

ЗАЙЛУУР зайлдаг юм; *шүдний зайлуур; зайлуур эм.*

ЗАЙЛШГҮЙ заавал, гарцаагүй; *зайлшгүй үйл; хийх нь зайлшгүй; зайлшгүй үнэн.*

ЗАЙМРААЧ зайлж займрахдаа чадамгай.

ЗАЙМРАГЧ займраач.

ЗАЙМРАХ 1. юмнаас зайлсхийх, булгарах; *ажлаас займрах;* **зайлах займрах** х о р ш.; 2. биеэ сажих; *биеэ битгий займраад бай!.*

ЗАЙМРУУЛАХ 1. займрахын үйлдүүлэх хэв; 2. түлхэлхийлэх, түлхцэх.

ЗАЙР I заарь.

ЗАЙР II усан дээгүүр өрөмтөн хөлдсөн нимгэн мөс; *зайр тогтох; зайр гүйх.*

ЗАЙРАН бөө хүн.

ЗАЙРМАГ дутуу хөлдсөн юм; *зайрмагтай дс; зайрмаг суух; сүүн зайрмаг.*

ЗАЙРМАГТАХ шингэн нялцгай юмны хөлдөж эхлэх.

ЗАЙРМАГТУУЛАХ зайрмагтахын үйлдүүлэх хэв.

ЗАЙРТАХ зайр бий болж тогтох.

ЗАЙРТУУЛАХ зайртахын үйлдүүлэх хэв.

ЗАЙСХИЙГҮҮЛЭХ хүнийг биений ойр болгохгүйг хичээх.

ЗАЙСХИЙХ 1. ойх, зайлах; 2. баахан зайх; 3. холхон болох.

ЗАЙТАЙ 1. аливаа юмны багтаамжтай; *зайтай гэр; зайтай байшин;* 2. юмны эв нийцгүй харилцан сарниу болсон, зай гарах; 3. зальтай, мэхтэй хүн, сийтэй; *зайтай хүн;* 4. алс хол; *зайтай газар.*

ЗАЙХ 1. дэмий сэлгүүцэн хэсэх; *дэмий зайх хэрэггүй;* 2. уул зэргийн эрс хатуу газраар ташуу жишиж явах; *өндөр уулын хажуугаар зайж явах.*

ЗАЙЦ дээвэр цаваг хоёрын завсар.

ЗАЙЦАХ зайтай болгох, зайчлах.

ЗАЙЦУУЛАХ зайцахын үйлдүүлэх хэв.

ЗАЙЧЛАХ зай гаргах; *агуулахын юмыг зайчлах.*

ЗАЙЧЛУУЛАХ 1. зайчлахын үйлдүүлэх хэв; 2. зайчлагдах.

ЗАЙЧУУР гэрийн хоёр дээврийн зөрүүлэг уулзар.

ЗАЛАА I 1. малгайн оройд хадах улаан ёнхор буюу улаан үс; *малгайн залаа;* 2. тугийн ишний дээд үзүүр этгээдэд хийх утас хялгас; *тугны залаа;* 3. будүүн ширхэгтэй ёнхор утас; **тахианы залаа** (тахианы толгой дээр орших махан цэцэг мэт юм); **тарианы залаа** (тариаяны түрүүгийн сахал өвс).

ЗАЛАА II богт чөмөг; *залаа чөмөг.*

ЗАЛААЛАХ залаа бий болох.

ЗАЛААЛУУЛАХ залаалахын үйлдүүлэх хэв.

ЗАЛАГДАХ залахын үйлдэгдэх хэв, залуулах.

ЗАЛАЙД өвөр монголын нэгэн аймгийн нэр.

ЗАЛАН хуурцирсан 1. урьдын цагийн тушмэнийн хэрэгсэм; 2. нэг ангийн цэргийг нэг залан цэрэг.

ЗАЛАХ I гажуу буруу, муруй хазгайг засах, залруулах, тэгшитгэх; *буруу зөрүүг засч залах; дүрга залах.*

ЗАЛАХ II 1. урьж ирүүлэх; *эмч залах; эрдэмтнийг залах;* 2. чухал хэрэгцээт зүйлийг авах, авчрах; *эм залах, үнэртэн залах.*

ЗАЛАХ III малыг билчээрт гаргах; *мал залах; үхрээ залах.*

ЗАЛБИРАЛ залбирах үйлийн нэр; итгэл даатгал; *залбирал даатгал хийх.*

ЗАЛБИРАХ шашны ёсонд ямар нэгэн юманд итгэж сүслэн даатгах.

ЗАЛБИРУУЛАХ залбирахын үйлдүүлэх хэв.

ЗАЛГАА 1. аливаа юмны залгасан газар; 2. юмны хойтох нь урьдахтайгаа дараа дараагаар тасралтгүй үргэлжилсэн нь; 3. үс гэзгэнд хийх үсээр хийсэн нэмэр буюу утсан цацаг; *гэзэгний залгаа.*

ЗАЛГААДАС залгаас.

ЗАЛГААС юманд залгасан юм; *дүрганы залгаас; гэзэгний залгаас.*

ЗАЛГАГЧ юмыг залгах этгээд; *шүгам залгагч.*

ЗАЛГАЛДАА юмны хойтох нь урьдахтай дараа дараагаар үргэлжилсэн нь.

ЗАЛГАЛДААГААР залгаа залгаагаар.

ЗАЛГАЛДАХ залгахын үйлдэлдэх хэв.

ЗАЛГАЛДУУЛАХ залгалдахын үйлдүүлэх хэв.

ЗАЛГАМЖ залгаж авах юм; *бидний залгамж үр хүүхэд; намын залгамж эвлэлийн гишүүд.*

ЗАЛГАМЖЛАГЧ залгамжилж авах хүмүүс; *эвлэлийн хойчийг залгамжлагч пионер мөн.*

ЗАЛГАМЖЛАХ 1. залгах; 2. юмны урьдахаас хойтох үед шилжин уламжлах; *ус залгамжлах; хойчийг залгамжлах.*

ЗАЛГАМЖЛУУЛАХ залгамжлахын үйлдүүлэх хэв.

ЗАЛГАХ 1. хоёр юмыг нийлүүлэх, холбож нэгтгэх бас хоёр юмны зах уулзар нийлэх; *даэс залгах; дүрга залгах; утас залгах; зах*

залгах; ширээнд хөл залгах; байшин залгаж барих; хил хязгаар залгах; нутаг залгах; 2. нэг юмны дараа нөгөө юм үргэлжлэх; *өвлийн дараа хавар залгах; хадлангийн ажил дуусмагц хээлтүүлгийн ажил залгах;* 3. тасалдсан дутагдсан хэрэглэгдэхүүн зүйлийг **нөхөн** гүйцэлдүүлэх; *өл хоол залгах; унаа залгах; шатахуун залгах; түлээ залгах;* 4. завсарласан зогссон юм дахин үргэлжлэх; *залгаж бичих; залгаж хуралдах; залгаж хэлэх;* 5. ор суурь эзлэх; *зэрэг хэргэм залгах; намын хойчийг залгах.*

ЗАЛГИДАГ ховдог шунахай; *залгидгийн гэрт хоолгүй, залхуугийн гадаа түлээгүй* з ү й р.

ЗАЛГИЛАХ шингэн юмыг түргэн түргэн залгих; *ус залгилах; айраг залгилах.*

ЗАЛГИЛУУЛАХ залгилахын үйлдүүлэх хэв.

ЗАЛГИУЛАХ залгихын үйлдүүлэх хэв.

ЗАЛГИХ идээ ундааны зэрэг зүйлийг амнаас хоолойгоор гулгуулан илгээх; *ангайх амтай залгих хоолойгүй* о н ь с г о; **шүлсээ залгих** (ховдоглон шунах).

ЗАЛГУУЛАХ залгахын үйлдүүлэх хэв, алба нийлүүлэх; *алба залгуулах; өртөөний алба залгуулах; сүү мах залгуулах.*

ЗАЛГУУР залгаж холбоход хэрэглэдэг хэрэгсэл; *утасны залгуур; залгуур гэрэл.*

ЗАЛИЛАГДАХ залилахын үйлдэгдэх хэв, мэхлүүлэх, мэхлэгдэх.

ЗАЛИЛАХ хууран мэхлэх, заль хэрэглэх.

ЗАЛИЛУУЛАХ 1. залилахын үйлдүүлэх хэв; 2. залилагдах.

ЗАЛИРАХ баахан ташаалсхийх төлөв; *бороо залирах; үүл залирах.*

ЗАЛИРХАГ заль мэх ихтэй.

ЗАЛИРХУУ залирхаг, зальтай.

ЗАЛЛАГА урилга; **урилга заллага х о р ш.**; *заллага айлтгах.*

ЗАЛМА 1. эртний хүмүүс уул хээрт чулуу мод цогцлон чимэглэж байгуулсан овоо; **овоо залма х о р ш.**; 2. тайж тахиглах буюу тэмдэг болгох, шивээ хороо хийхийн тул байгуулсан овоо.

ЗАЛМАГАЙ загасны шанаа дахь амьстах эрхтэн болох давхар давхар юм; *залмагайт амьтан.*

ЗАЛМАЙ залмагай.

ЗАЛРАХ I 1. гажуу буруу, сөргүү цалгай юм засарч сайн болох, зөвд орох; 2. муруй хазгай юм шулуусах, тэгшрэх; 3. муу дорой, болхи бүдүүлэг юм засарч сайжрах; 4. алдаа ташаа арилж засрах.

ЗАЛРАХ II хүний ирэх, очих, үхэхийн хүндэтгэл; *заларч ирэх; заларч явах; тэнгэрт залрах.*

ЗАЛРУУЛАХ залрахын үйлдүүлэх хэв; засрах залрахад хүргүүлэх.

ЗАЛРУУЛГА залруулсан юм; **номын залруулга** (номын алдаа мадгийг залруулсан хавсралт).

ЗАЛТАС хагадас мод.

ЗАЛУУ хүн амьтан буюу мод ургамлын зэрэг амьд юмны нас **хөгшрөөгүй** идэр байгаа нь; *залуу хүн; залуу нас; залуу мод; залуу болох.*

ЗАЛУУДАХ хэтэрхий залуу болох.

ЗАЛУУДУУЛАХ залуудахын үйлдүүлэх хэв.

ЗАЛУУМСАГ залуу зантай.

ЗАЛУУР 1. муруй мод зэргийг шулуутган засахад хэрэглэдэг багаж; 2. хөлөг онгоц, нисэх онгоц, автомашин зэрэг юмны зүг чигийг тохируулах бариул; *залуу жолооч залууараа бариад замын уртыг ширтэнэ.*

ЗАЛУУРАХ улам залуу болох.

ЗАЛУУРУУЛАХ залуурахын үйлдүүлэх хэв.

ЗАЛУУРХАГ залуумсаг.

ЗАЛУУРХАХ 1. залуудаа эрдэж омогших; 2. залуу зан байдал гаргах.

ЗАЛУУРХУУ залуу мэт төлөвтэй.

ЗАЛУУРХУУЛАХ залуурхахын үйлдүүлэх хэв.

ЗАЛУУС залуу хүмүүс.

ЗАЛУУХАН нилээд залуу, баахан залуу; *манай нэгдлийн даргаар нэг залуухан эр ирэв.*

ЗАЛУУЧУУД залуус; *залуучуудын эвлэлийн байгууллага; энгийн залуучууд; малчин залуучууд.*

ЗАЛХААЛГА хал үзүүлж хаширгасан нь.

ЗАЛХААЛГАХ 1. залхаахын үйлдүүлэх хэв; 2. залхаагдах.

ЗАЛХААЛТ залхаамж.

ЗАЛХААМЖ залхаасан нь; *залхаамж үзүүлэх.*

ЗАЛХААТАЙ төвөг ихтэй, зовлон зүдүүртэй; *залхаатай ажил; залхаатай амьтан .*

ЗАЛХААХ залхахын үйлдүүлэх хэв; *залхаан цээрлүүлэх.*

ЗАЛХАГ I хүн амьтны ааль байдал гавшгай эелдэггүй, болхи бохир буюу залхуу хашин.

ЗАЛХАГ II нус идээр мэт норшин нялгар юм.

ЗАЛХАЙ салан задгай, цалгар назгай.

ЗАЛХАЛ залхах нь; **хашрал залхал** х о р ш.

ЗАЛХАЛТ залхамж.

ЗАЛХАМЖ залхсан, цээрлэл шийтгэл.

ЗАЛХАМЖГҮЙ айх залхахыг огт мэдэхгүй, хаширдаггүй.

ЗАЛХАХ 1. ямар нэгэн үйл явдлын урьдахад хаширч хойшид хянамтгай болох; 2. ямар нэгэн үйл явдлаас хашрах; *энэ түр түр хийсэн дуунаас би залхаж байна.*

ЗАЛХЛАГА залхсан нь.

ЗАЛХУУ аливаа үйл хэрэгт хичээнгүй биш, ажил хөдөлмөрт дургүй, хойш суух хойргошших зантай; *залхуу хүн, завааг дахь махандаа хүрдэггүй* з ү й р; *залхуу хүрч байна.*

ЗАЛХУУГҮЙ залхуурахыг мэдэхгүй, огт зүгээр байж чаддаггүй; *залхуугүй хүн заавал нэгийг бүтээдэг.*

ЗАЛХУУРАХ аливаа үйл үйлдвэрт хичээн зүтгэхгүй хойргошин хойш суух; *ажилд биггий хойш сууж залхуурч байгаарай.*

ЗАЛХУУРУУЛАХ залхуурахын үйлдүүлэх хэв.

ЗАЛХУУТАЙ дур сонирхолгүй, залхуу хүрмээр байдалтай; *залхуутай яриа; залхуутай ажил.*

ЗАЛХУУЧ ямагт хойш суумтгай зантай.

ЗАЛЬ 1. арга мэх; **арга заль мэх заль** х о р ш.: 2. цог; **цог заль** х о р ш..

ЗАЛЬДАХ бусдыг аргалан хууран явах, залилах.

ЗАЛЬДУУ залирхуу байдалтай.

ЗАЛЬСАГ залилах зантай.

ЗАЛЬТ заль бүхий.

ЗАЛЬТАЙ арга мэх ихтэй.

ЗАЛЬХАЙ 1. зусар мэхлээч; *зальхай дайсан;* 2. самуун цалхай; *зальхай самуун.*

ЗАМ I 1. амьтан юмны явах зорчиход зориулсан юм; *дардан зам; зөрөг зам; тээврийн зам; тэрэгний зам; Улаанбаатарын зам; Бээжингийн зам;* 2. зүг чиг, төрөл; *баруун замын байлдаан; хуурай замын цэрэг; усан замын цэрэг;* 3. мөрдлөг, хөдөлбөр; *Лениний заасан зам;* 4. арга, сүв; *хэлэх замтай; зайчих зам байлгүй яах вэ;* **олны зам** (нийт буюу олонхийн явах зорчих газар); **хөл зам, зам хөл** (олны зам мөрт тохиолдох газар); **хөлтэй зам** (олон амьтны хөл ихтэй, үймээн шуугиан ихтэй зам); **дөт зам** (ойр чиг зам); **тойруу зам** зорьсондоо хүрэхэд дөт чиг биш зам, хол зам); **улбаа зам** (үл мэдэгдэх шахам замын ором); **зөрөг зам** (явах зорчих нарийн зам); **жим зам** (тодорхой биш нарийн зам); **чарга зам** (малын цуваагаар гарсан нарийн ором); **зам огтлох** (зам хөндлөн гарах); **зам сахих** (а. замын ойр нутаглах; б. зам тосон хүлээх); **зам тосох** (а. зам отож булаан дээрэмлэх; б. уулзах учрахаар зам уттаж хүлээх); **зам гажих** (а. замаас гарч явах; б. үйл явдал үл тохирох); **зам зуур** (замын гудас, замд явах үед); **зам мөр** (а. мөр; б. дагаж мөрдөх зүйл); **зам заагч** (зам заадаг хүн); **зам бөглөх** (а. зам дээр тотгор хийх; б. ажил үйлд боомт болох); **зам гарах** (а. замын ором гарах; б. дагах дууриах мөр гаргах; в. зам хөндлөн гатлах); **зам хөөх** (а. зам мөрийг мөшгөх мөрдөх; б. замыг яг дагаж явах); **зам хаах** (а. зорчихыг хориглох; б. үйл ажлын явцад саад тотгор хориг тавих); **зам нийлэх** (а. явдлын зам нэгдэх; б. үйл ажил нэгдэх; в. салбар зам, их замд нэгдэх); **замаа алдах** (а. төөрч будлих; б. ажил явдал буруудах); **явах зам** (а. зорчих зам б. урагшлах мөр); **харгуй зам** (дардан зам; **зам харгуй** х о р ш .); **алсын зам** (а. холын зам; б. хэтийн зам, ирээдүйн зам, хүрэх зам); **дардан зам, зам дардан** (а. олны зорчих тодорхой их зам; б. үйл үйлдвэрт саад бэрхшээл байхгүй); **агаарын зам** (нисэх онгоцны зам); **төмөр зам** (төмрөөр хийсэн зам); **усан зам** (усаар явах зам); **хуурай зам** (газраар явах зам); **цардмал зам** (цардаж хийсэн зам); **засмал зам** (зориуд зассан зам); **зөв зам** (а. зорьсон газарт хүргэх зам: б. явбал болох үйл явдал); **буруу зам** (а. зорьсон газар үл хүрэх зам; б. үл болох үйл явдал); **зам явах** (гэмгүй, энгийн, мөрөөрөө; *гэм яваагүй, зам явна*); **зам явах бичиг** (ямар хэргээр яваах тодорхойлсон албан баримт); **төв зам** (гол зам); **тойрог зам** (тойруу зам); **салаа зам** (салбар зам); **улаан зам** (дэлхийн бөмбөрцгийн зураг хоёр туйлыг

тэгш хувааж голоор нь татсан шугам); **замын гудас** (замын дагуу); **замын сахиул** (а. замын ойр нутаглах айл: б. замын харгалзагч); **замын гэмдэг** (зам дээр тавьсан таних тэмдэг); **замын хань** (а. аян явдалд нөхөр болж явагч; б. үйл ажилд түр зуурын нөхөр болгон ашиглах хүн); **замын хамар** (элэгдэж ором гарсан замын мөрүүдийн хооронд хотойгоогүй товойж үлдсэн газар, зарим газар замын шан гэнэ); **замын гэр** (замын ойролцоо сууж аж төрөх айл гэр); **замын билчир** (замын уулзар); **замын уулзар** (зам нийлсэн газар); **замын хүнс** (замд идэж уух юм); **улаан зам дээр** (яг зам дээр).

ЗАМ II хуучирсан тогооч; жасын зам.

ЗАМАА орны дээдэд татах хөшиг; баруун зүүн ар дээд дөрвөн эгээдийг битүү, нүүр эгээдийг битүүлэвч сөхөвч болохоор хийсэн хөрх.

ЗАМАГ I усны дотор ургадаг ургамлын нэр, их төлөв өнгө ногоон ба цайвар бий; *замагтай нуурт шувуу цуглана.*

ЗАМАГ II бууны сумыг гол төмөрт оруулах ба хэнгиог хөөж гаргадаг хэрэгсэл; *буугны замаг; замаг гацах.*

ЗАМАГДАХ 1. замгаас барих; 2. хэтэрхий замагтай болох.

ЗАМАГЛАХ I усны замаг нэмэгдэх.

ЗАМАГЛАХ II бууны замгийг хийж бэлтгэх.

ЗАМАГЛАХ III ялгум морь малын явцав хийн хөдлөө гэж тогтон ядаж аашлах.

ЗАМАГРАХ замаг болох.

ЗАМАГТАХ замаг тогтох, замагтай болох.

ЗАМАГТУУЛАХ замагтахын үйлдүүлэх хэв.

ЗАМАГШИХ замаг ихтэй болох, замаг шинжтэй болох.

ЗАМАЛ ургамал навч баахан ихээхэн нэгэн зүйл өвс.

ЗАМАН: **заман луус** илжигнээс төрсөн луус.

ЗАМАР ургамал өнгө улаан, амт амтайхан, цэцгийн үнэр, өнгө сайхан нэгэн зүйл жимс; **замар цэцэг** ургамал (бут бутаар ургана, ишиндээ сондуутай, өнгө улаан, үнэр сайн).

ЗАМБА I ургамал бут богино, навч зузаан, цэцэг зоосын адил, гилтэгнэм хээ сайхан, өнгө улаан, цайвар улаан, цайвар хүрэн гурван янз байдаг.

ЗАМБА II: **замба гүрвэл** амьтан могой гүрвэл мэт болоод түүнээс том нэг зүйл гүрвэл.

ЗАМБАА арвайн гурил.

ЗАМБАГА ургамал мөнх ногоон бутлаг мод мөн түүнээс ургадаг хуйт цэцэг.

ЗАМБАЛЗАГУЙ баяр ёслолын зэрэгт хаалга үүд буюу орон савд өлгөх нэгэн зүйл чимэг, торго бөсийн зэргээр цэцэг цоморлогийг дүрэмлэн хийнэ.

ЗАМБАЛЗУУР замбалзагуй чимэглэл.

ЗАМБАРАА эмх цэгц; **эмх замбараа** хорш.

ЗАМБАРААГҮЙ эмх цэгцгүй, эх толгойгүй; *эмх замбараагүй байна.*

ЗАМБАРААТАЙ эмхтэй, цэгцтэй, журам дэглэмтэй.

ЗАМБАТИВ замбуулин.

ЗАМБУУЛИН манай дэлхийн өөр нэр.

ЗАМГҮЙ зам мөр байхгүй; *явах замгүй; замгүй газар;* 2. аргагүй, боломжгүй; *зайлах замгүй; арга зам байхгүй; замгүй хэрэг;* 3. маш олон; *бүр замгүй олон ном байна.*

ЗАМНАЛ замнах үйлийн явц, замнах үйлийн нэр.

ЗАМНАХ 1. нэгэн замаар нэмэн нэмэн явах буюу байн байн явах; 2. аливаа юмыг мөрдөн явах.

ЗАМНУУЛАХ замнахын үйлдүүлэх хэв.

ЗАМРААХ замруулах, замрахад хүргүүлэх.

ЗАМРАХ I өнгөрөх, болих, зогсох, дуусах, төгсөх.

ЗАМРАХ II буцалсан цай ус зэрэг юмыг самрах.

ЗАМРАХ III үйл ажил удрах, задрах; *миний ажил гэж замарч гүйцлээ; мөн ч замарсан хэрэг болж байна.*

ЗАМРУУЛАХ замрахын үйлдүүлэх хэв.

ЗАМТАЙ 1. зам бүхий; 2. аргатай, боломжтой; *явах замтай, хэлэх үгтэй.*

ЗАМХ эмх замбараа; *эмх замхгүй задгай данс.*

ЗАМХАР ургамал ишиндээ сондуутай, навч замар цэцгийн адил болоод цайвар хүрэн, сайхан үнэртэй.

ЗАМХРААХ замхрахад хүргүүлэх.

ЗАМХРАХ 1. юм сарниж үгүй болох; *тоос замхрав; хөөс замхрав;* 2. завхрах; *нөгөө ажил замхрав.*

ЗАМХРУУЛАХ замхрахын үйлдүүлэх хэв.

ЗАМЧ (ИН) 1. зам заагч; 2. зам засагч.

ЗАМЧЛАХ зам зааж явах.

ЗАМЧЛУУЛАХ замчлахын үйлдүүлэх хэв.

ЗАМШИХ 1. зам гарах; 2. зам шинжтэй болох; 3. журамших, занших.

ЗАН I 1. хүн амьтны аашлах байдал төлөв; **зан ааль, зан байдал, зан суртал, зан заншил** хорш.; *сайхан зан; муухай зан;* **догшин зан** (хэдэр хэрцгий зан); **даруу зан** (түвшин төлөв зан); *зан сайт хүнд хүн болгон цуглана, замаг сайт усанд шувуу болгон цуглана* хууч.; **их зан** (ихээр, ихэмсэг, тоомсоргүй зан байдал); **олон зан** (хялбархан хувирах тогтворгүй ааш зан); **зан заншаа авалцах** (харилцан зан байдлаа мэдэлцэх); 2. ая, үйл ажил; **ая зан** хорш.; **ая зан юу хийж байна?** (ямар үйл ажил эрхэлж байна?); **зан суртахуун** (ямар нэгэн нийгэмлэгийн шаардлагад тохирох хүний ааль, авир, дүрэм, төлөв); **зан суртал** (уламжлан заншиж ирсэн ёс, дүрэм, хүн ард нийтээр хүлээн зөвшөөрсөн дадал заншил).

ЗАН II гутал шааврын уланд нөхөх бэхлэхээр тавих юм; *зан шир; зан төмөр;* **зан тавих** (гутлын уланд шир зэргийг давхарлан оёх хадах).

ЗАНА амьтан эр эм хоёрын өнгө зүс хоёр өөр; эрийн элгэн тал час улаан, эмийн элгэн тал бор саарал, модонд амьдардаг шувуу; **улаан зана** амьтан (мод бутны мөчир дээр үүрлэдэг нэг зүйл болжмор шувуу).

ЗАНАА I занах үйлийн нэр, хорсол, занал, санаа.

ЗАНАА II ам захиа; **захиа занаа** хорш.; *захиа занаагий нь сайн өгөөрэй; захиа занаагий нь эздэд нь олгож өгье.*

ЗАНААТАЙ 1. занал хорсол бий; *чи над занаатай байна уу?;* 2. бэлтгэлтэй, бодолтой, анаж цэнэсэн нь; *энэ бол бүр ч занаатай үйлдсэн хэрэг.*

ЗАНАЛ занах үйлийн нэр, хадгалсан хорсол; *занал нь тун их байгаа болоолтой.*

ЗАНАЛТ занал бүхий, занасан нь; *заналт дайсан; заналт этгээд.*

ЗАНАР тунамал ба хайлмал чулуулгаас үүсэн бүрэлддэг нэг зүйл чулуулаг; зарим нь нимгэн үеэр давхраатаж тогтсон байдаг, талст хэлбэртэй ч байх нь бий; **шатах занар** (хий зэрэг зүйлийг нэрэхэд хэрэглэдэг шатах чанартай занар); **талст занар** (хайлмал чулуулгаас үүссэн нэг зүйл чулуулаг).

ЗАНАХ 1. бусдад хорсч тачаадан өшөө хонзон санах; *өшөөтнөө занах; дайсныг занах;* 2. буруушаан донгодох, зандрах; *аав намайг занаж зэмлээд явлаа.*

ЗАНГА ан агнахад хэрэглэх зэвсэг, торсон ан амьтныг дарж боож үхүүлнэ, олон янз байдаг; *хулганын занга; зурамны занга; үнэгний занга;* **занга зүүх** (барих алах ан амьтан заавал өртөж торох газар зангаа тохируулан тавих); **занга нум** (тусгай юмаар бариул тавихгүй дан үхрийн эврээр нийлүүлэн хийсэн жижиг нум).

ЗАНГАДАХ занга тавьж агнах; зангадаж барих.

ЗАНГАДУУЛАХ зангадахын үйлдүүлэх хэв.

ЗАНГАЙЛГАХ зангайхын үйлдүүлэх хэв.

ЗАНГАЙХ хүний гачигдахад яах арга огт олдохгүй болох.

ЗАНГАЛАЙ I амьтан богширгын чинээ биетэй, бие чандар эрээн нэгэн зүйл шувуу.

ЗАНГАЛАЙ II үг хэлэлцэхдээ түлбэрэмтгий, амандаа юм үмхчихсэн юм шиг байдалтай; *яриа муутай зангалай хүн дээ, тэр чинь.*

ЗАНГАЛАЙТАХ хүний үг хэлэлцэхэд хэл нь ээдрэх буюу хоолой чаргадах зэргээр эв эегүй болох; *зангалайтсан хайшаа хүн бэ?.*

ЗАНГАЛАХ I байн байн зангах.

ЗАНГАЛАХ II 1. юманд занга зүүх; 2. юмыг тойрон хоргоож хорих, барих.

ЗАНГАРАХ хүний уур хилэн бадарч муухай дуугаар зандрах.

ЗАНГАХ 1. гараар буюу элдэв юмаар нөгөө юманд хүрэх, шүргэх дэлдэх зэргээр хөнөөхийг завдах: 2. цохлон заах; заах зангах хорш..

ЗАНГИ I хуучирсан сум буюу харуул өртөө зэргийг захирах хүний албан тушаалын нэр; *сумын занги; харуулын занги.*

ЗАНГИ II мэдээ, сураг; **сураг занги, мэдээ занги** х о р ш.

ЗАНГИ III хөвөрхий биш уяа; **занги уяа;** (зангидах); **занги бялзуухай** а м ь т а н (шаазгайгаас багахан, хүзүү ар бараан, хоёр салаа урт сүүлтэй нэгэн зүйл шувуу).

ЗАНГИА 1. зангилаа, зангилгаа; 2. шашны ёсонд хүнд зүүлгэхээр зангидсан хив хадаг; *зангиа сахиус; адис зангиа;* 3. хүний хүзүүнд зүүхэд зориулан хийсэн нэгэн зүйлийн чимэглэл; *зангиа зүүх;* **зангиа цэцэг** у р г а м а л (янз билэгт цэцгийн адил, өнгө тунгалаг шар, салаа уян, зангидаж болдог, зулгарч навч ургана).

ЗАНГИАС 1. зангидсан зангилаа; 2. зангиа.

ЗАНГИАСЛАХ 1. дээс утас зэргийн юмыг уях зангидах; 2. зангиа зүүлгэх.

ЗАНГИДАХ 1. юмыг зангиаслан уях; *утас зангидах; хазаар зангидах; ногт зангидах; зангидаж уях;* 2. ш и л ж с э н атриулах, үрчийлгэх, хумих, атгах; *хөмсөг зангидах; шазуур зангидах; гараа зангидах;* 3. ш и л ж с э н бөөн болгож хуралдуулах; *бүх хүчээ зангидаж ажиллацгаая!;* ☆ **аман хүзүү зангидах** (нэг зүйл уяа).

ЗАНГИДУУЛАХ зангидахын үйлдүүлэх хэв, зангидахад хүргүүлэх.

ЗАНГИЛАА 1. зангидсан зангиас; *зангилаа тайлах; зангилаагий нь гаргах;* 2. уулзар газар; *төмөр замын зангилаа; радио зангилаа.*

ЗАНГИЛААС зангиас.

ЗАНГИЛАХ юмыг зангидах, занги болгох; *зангилж уях.*

ЗАНГИЛУУЛАХ зангилахын үйлдүүлэх хэв.

ЗАНГИРАХ 1. юмны зангилаа улам чангарах буюу занги болох; *утас зангирах; олс зангирах;* 2. ш и л ж с э н юмны зангирсан мэт болох, санагдах, тээглэх, ээдрэх, ороолдох; *хоол зангирах; хоолой зангирах; дотор зангирах; хий зангирах; гэдэс зангирах.*

ЗАНГИРУУЛАХ зангирахын үйлдүүлэх хэв, занги болгох.

ЗАНГУУ I ургамал усанд буюу уулын хярын жалга зав, гүвээ хоолой хонхор газар ургах хоёр зүйл бий; дэрсний хир бүдүүн иштэй, газраар наалдан зэллэж ургадаг, шар цэцэгтэй, тагнайран хэлхэлсэн жижиг хавтгай навчтай, эвэртэй ямаан толгойн хэлбэртэй үртэй, үрийн үзүүр тутам хурц өргөстэй ургамал; хонин зангуу, нохой зангуу гэх зэрэг ялгал бий, заримын цөмийг идэж болно.

ЗАНГУУ II: **зангуу төмөр** онгоц, галт тэрэг зэргийг зогсоох гох төмөр; *зангуу хаях.*

ЗАНГУУ III баавгай, мангис зэргийг агнахад хэрэглэдэг нэгэн зүйл зэвсэг; *баавгайн зангуу.*

ЗАНГУУДАХ зангуу тавьж агнах; *баавгай зангуудаж агнах.*

ЗАНГУУРГА I мангис элбэнх зэргийг агнахад хэрэглэх зэвсэг; *элбэнхийн зангуурга.*

ЗАНГУУРГА II ам нь хэтэрхий хатуу, байдал хэрцгий, үгээр егөх зантай; *зангуурга үг; зангуурга зан; зангуурга байдал.*

ЗАНГУУРГАДАХ зангуургаар агнах; *элбэнх зангуургадах.*

ЗАНГУУРГАЛАХ зангуургатай зан байдал гаргах; *тэр гуай чинь дандаа егөж зангуургалаад яасан төвөгтэй юм бэ дээ.*

ЗАНГУУРГАТАЙ зангуурга бүхий; *тун ч болдоггүй зангуургатай хүн юм, хэлж байгаа үгний нь зангуургатайг хэлээд яах вэ.*

ЗАНГҮЙ I олон аашгүй, сайхан зантай, их зантай биш.

ЗАНГҮЙ II огт хөдөлбөргүй, бүтэхгүй, чадахгүй, дийлэхгүй; *түүнийг ажил хийлгэх гэсэн чинь зангүй; том чулууг өргөх гэсэн чинь зангүй шүү, хөдөлгөдөг ч үгүй; нэг номы нь авъя гэж хичнээн гуйсан болович огт зангүй.*

ЗАНДАЛЧ (ИН) дээрэмчин, тонуулчин зэрэг муу үйлээр амьдрагч; **зандалчин язгуур** (ичгүүр сонжуургүй алах хулуух мэтийн муу үйлээр амьдрагчдын язгуур).

ЗАНДАН у р г а м а л халуун оронд ургадаг, анхилам үнэрт мод; *цагаан зандан, улаан зандан; хүрэн зандан; зандан шатар; зандан ширээ.*

ЗАНДАХ өндөр дуугаар зандрах; *хориглон зандах; бурууштаан зандах; чимээгээ намд гэж зандах.*

ЗАНДАРГАХ зандрахад хүргүүлэх, зандруулах.

ЗАНДРАХ бусдад сүр үзүүлэн өндөр дуугаар хэлэх, өгүүлэх; *айлган зандрах; хилэгнэн зандрах.*

ЗАНДРУУЛАХ 1. зандрахын үйлдүүлэх хэв; 2. зандрагдах .

ЗАНДУУЛАХ 1. зандахын үйлдүүлэх хэв; 2. зандагдах.

ЗАНТАЙ I зан бий, зан ихтэй; *зан сайтай; зан муутай; их зантай; зан сайтад хүн бүхэн цуглана.*

ЗАНТАЙ II дээд сайн чанартай; *зантай сайн эд; зантай сайхан хоол; зантай гоё хүүхэн.*

ЗАНТАЙЛГАХ зантайхын үйлдүүлэх хэв, зантгар болгох.

ЗАНТАЙХ зантгар болох; *зантайсан том толгойтой.*

ЗАНТАЛЗАХ зантгар юмны байн байн хөдлөх.

ЗАНТАЛЗУУЛАХ занталзахын үйлдүүлэх хэв.

ЗАНТГАНАХ зантгар юмны үргэлжлэн хөдлөх.

ЗАНТГАНУУЛАХ зантганахын үйлдүүлэх хэв.

ЗАНТГАР нэгэн этгээд данхар бүдүүн, том; *зантгар толгойтой;* **зантгар загас** а м ь т а н (халуун орны тэнгэс, гол мөрөнд орших нэг зүйл загас, авлаж хэрэглэнэ).

ЗАНУУЛАХ 1. занахын үйлдүүлэх хэв; 2. занагдах.

ЗАНХАЙЛГАХ занхайхын үйлдүүлэх хэв, занхгар болгох.

ЗАНХАЙХ занхгар болох.

ЗАНХАЛЗАХ занхгар юмны байн байн хөдлөх.

ЗАНХАЛЗУУЛАХ занхалзахын үйлдүүлэх хэв.

ЗАНХГАНАХ занхгар юмны үргэлжлэн хөдлөх.

ЗАНХГАНУУЛАХ занхганахын үйлдүүлэх хэв.

ЗАНХГАР зантгар, загзгар; *занхгар толгойтой; занхгар ус.*

ЗАНХГАРДАХ хэтэрхий занхгар болох.

ЗАНЧИХ зодох, цохих, дэлдэх.

ЗАНЧУУЛАХ занчихын үйлдүүлэх хэв, зодуулах, цохиулах, дэлдүүлэх, жанчуулах.

ЗАНЧУУР дэлдэх занчих зэвсэг; *занчуур мод; занчуур ташуур.*

ЗАНШААХ заншихад хүргүүлэх, заншил болгох; *бид тэгж заншаагүй.*

ЗАНШИЛ хэв журам болсон юм; *урьдын заншил; одоогийн заншил; хуучин заншил; шинэ заншил;-заншил болох.*

ЗАНШИХ хэвшиж заншил болох; *цагаан идээ идэж занших; загас идэж занших; биеийн тамир хийж занших; өдөр унтаж занших; явж занших.*

ЗАНШЛАГА 1. заншил, хэвшил; 2. занших үйлийн нэр.

ЗАНШЛАГЧ юм сонирхож сурвалжлан явагч; *заншлагч миний олж мэдсэнээр... .*

ЗАНШЛАХ юм сонирхож сурвалжлан хэсүүчлэн явах; *газар орон хэсч заншлах; далайгаар заншлах; заншлаар явах.*

ЗАНШЛУУЛАХ заншлахын үйлдүүлэх хэв, заншлахад хүргүүлэх.

ЗАНШУУЛАХ заншихын үйлдүүлэх хэв, заншил болгуулах.

ЗАПАС нөөц юм; *машинын запас хэрэглэл.*

ЗАПАСЛАХ нөөц бэлтгэл болгох; *нуурс запаслах.*

ЗАПАСЛУУЛАХ запаслахын үйлдүүлэх хэв, нөөцлүүлэх, хуримтал болгож хадгалуулах.

ЗАР I олонд зарлан нийтлэх үг буюу мэдээ бичиг; *ухуулах зар; зар тараах.*

ЗАР II улаагаар явах эрх олгосон бичиг; *улааны зар.*

ЗАРАА 1. а м ь т а н биеийн гадуур зүү мэт эвэрлэг үстэй жижигхэн амьтан; **далайн зараа** а м ь т а н (биеийн хэлбэр дугуй, зараа мэт өргөсөн арьстай, ам нь биений доод талд бий, тэнгэс далайн гүнд амьдрах амьтан); **зараа уул** у р г а м а л (ой хээр талын бүсэнд ургана, навчны дор тал цайвар үстэй бөгөөд эргэн тойрон өргөстэй, үрийн сав бөөрөнхий, тод хөх өнгөтэй, тайжийн жинс ч гэнэ); 2. ш и л ж с э н муу зантай; *зараа шиг амьтан.*

ЗАРАГ I хэрэг; **хэрэг зараг** х о р ш..

ЗАРАГ II а м ь т а н цууцлайн нам, хушуу урт, хөл богино, өрөвлөг хөхөвтөрхөн, сүүлийн уг цагаан нэгэн зүйл шувуу.

ЗАРАГДАХ I зарцлагдах; *айлд зарагдах; бусдад зарагдаж амьдардаг байв.*

ЗАРАГДАХ II зарахын үйлдэгдэх хэв, худалдагдах; *дэлгүүрт зарагдахгүй бараа их байна; зах дээр зарагдаж байгаа зүйлийн гол нь хонь байв.*

ЗАРАМ I маш бүдүүн ширхэгтэй гурил, нүдэж тээрэмдсэн амуу тарианы талхарч чадаагүй бүдүүн ширхэгтэй байгаа нь; *гурилын зарам;* **зарам гол** (нарийлан шигшээд үлдсэн бүдүүн хэсэг).

ЗАРАМ II а м ь т а н загас хэлбэртэй, цаас иддэг нэгэн зүйл хорхой; *зарам хорхой.*

ЗАРАМ III а м ь т а н жижиг загас жараахай; *зарам загас.*

ЗАРАХ I 1. зарцлах, ямар нэгэн үйл ажлыг бусдаар хийлгэх; *албадан зарах; хөлслөн зарах;* 2. илгээх, явуулах; *элч зарах; хүн зарах; бичиг зарах;* 3. юмыг эдэлж хэрэглэх; *өртөө уяанд зарах морь; аян жинд зарах тэмээ; хоол хүнсэнд зарах хонь; орон сууцны хөлсөнд зарах мөнгө.*

ЗАРАХ II худалдах; *зарж худалдах; ариж зарах; унадаг дугуйгаа зарах; юм зарах.*

ЗАРГА харилцан заалдаж тэмцсэн тэмцэл; **зарга тэмцэл, зарга заалхай** х о р ш.; *зарга мэдүүлэх; зарга шийтгэх; зарга хагалах; зарга шүүх.*

ЗАРГАЛДААН заргалдах үйлийн нэр.

ЗАРГАЛДАХ зарга хийж тэмцэн заалдах.

ЗАРГАЛДУУЛАХ заргалдахын үйлдүүлэх хэв, заргалдахад хүргүүлэх.

ЗАРГАЧ 1. зарга тэмцэл хийхэд чадамгай; 2. х у у ч и р с а н зарга шүүх хүний албан тушаалын нэр; *амбасын заргач.*

ЗАРДАЛ зарж хэрэглэх юм; *хоолны зардал; бичгийн хэрэглэлийн зардал; замын зардал; бага зардал гаргаж ихийг бүтээх;* **төсөв зардал** х о р ш . .

ЗАРДАС зарц хүн; *хувьсгалын өмнө бусдын зардас болж явав.*

ЗАРДСАН зарц.

ЗАРИГДАА энгийн, жирийн, зүгээр; *зариг-даа явж байтал завшаанд чамтай тохиолдов.*

ЗАРИМ олны дотроос хагасыг бүхэлд нэг хоёрыг, эсвэл бүхэл бүтэн юмны хагасыг цохлон зааж хэлэлцэх үг; *зарим хүн; зарим хэрэг; зарим цаг үед; газар нутгийн зарим хэсэг; зарим нь тийм; заримыг ав; зарим орхи; зарим талаар хангалтгүй байна.*

ЗАРИМДАА хааяа хааяа; үе үе; үргэлжид биш; *заримдаа нойр хүрэхгүй; заримдаа сайн; заримдаа тустай; заримдаа хэрэггүй.*

ЗАРИМДАГ хагас, дутуу; *заримдаг сар; заримдаг хэлбэр;* **заримдаг гийгүүлэгч** (заримдаа эгшигтэй, заримдаа эгшиггүй ордог гийгүүлэгч.

ЗАРИМДАГЛАХ хагас дутуу болгож орхих, зэмдэглэх; *ажлаа заримдаглаад орхимоо.*

ЗАРИМДАГЛУУЛАХ заримдаглахын үйлдүүлэх хэв.

ЗАРЛАГА I албан ажилд зарагдах хүний тушаалын нэр; *сумын зарлага; сангийн яамны зарлага.*

ЗАРЛАГА II зарцуулах буюу зарцуулсан зардал юм; **орлого зарлага** х о р ш . ; *орлого зарлагын төсөв; зарлага болгох; зарлагад гаргах.*

ЗАРЛАГАДАХ зарлагад гаргах.

ЗАРЛАГАДУУЛАХ зарлагадахын үйлдүүлэх хэв.

ЗАРЛАЛ зарласан нь; *сонины зарлал; зарлал гаргах; зарлал нааж; зарлал тараах.*

ЗАРЛАХ аливаа хэрэг зүйлийг олонд тунхаглан сонсгох, мэдүүлэх; *нийтэд зарлах; сонинд зарлах; радиогоор зарлах; хурал зарлах; хууль зарлах; алба зарлах; зарлан дуудах; зарлан хуралдуулах; зарлан тушаах;* **дайн зарлах** (дайтахыг мэдэгдэх).

ЗАРЛИГ 1. улсын дээд эрхийг барих газраас гаргасан хуулийн чанартай шийдвэр; *их хурлын тэргүүлэгчдийн зарлиг;* 2. хаан хүний хэлсэн зарласан үг ба бичиг; *хааны зарлиг; эзний зарлиг;* 3. хүндэтгэвэл зохих хүний хэлсэн үг; *багшийн зарлиг; ноёны зарлиг; ламын зарлиг.*

ЗАРЛИГЛАХ зарлиг болох, зарлиг гаргах, зарлиг буулгах.

ЗАРЛУУЛАХ зарлахын үйлдүүлэх хэв.

ЗАРУУД өвөр монголын нэгэн аймгийн нэр.

ЗАРУУЛАХ 1. зарахын үйлдүүлэх хэв; 2. зарагдах, зарцлагдах.

ЗАРЦ бусдын эрхшээл нөлөөний дор захирагдан зарцлагдах хүн; *зарц болох; зарц зарах; хөлсний зарц; депутат хүн бол ард түмний зарц мөн.*

ЗАРЦЛАГДАХ 1. зарцлахын үйлдэгдэх хэв, 2. бусдад хүчээ өгч зарагдах; *урьд айлд зарцаар зарцлагдаж явав; одоо ард түмэндээ зарцлагдаж байна.*

ЗАРЦЛАХ аливаа үйл ажилд бусдыг зарц болгон хэрэглэх; *хөлслөн зарцлах; албадан зарцлах.*

ЗАРЦЛУУЛАХ 1. зарцлахын **үйлдүүлэх хэв**; 2. зарцлагдах.

ЗАРЦУУЛАГДАХ зарцуулахын үйлдэгдэх хэв; *төсөвт мөнгө зарцуулагдаад дууссан.*

ЗАРЦУУЛАХ аливаа юмыг зарж хэрэглэх; *бичгийн хэрэглэлийг зарцуулж дууссан; юмыг хэмнэн зарцуулж сурах хэрэгтэй.*

ЗАРЧ олонд зарлах үүрэг гүйцэтгэгч хүн; *театрын зарч.*

ЗАРЧИМ ямар нэгэн онол, сургал, шинжлэх ухаан, хууль дүрэм, хэв заншлын үндсэн зүй ёс; *зүй зарчим; ёс зарчим; цааз зарчим; зарчмыг дагаж явах; зарчмын асуудал; зарчмын дотор; зарчмын хувьд тохирохгүй.*

ЗАРЧИМГҮЙ журам дэглэмгүй, зүйгүй; *зарчимгүй явдал; зарчимгүй этгээд.*

ЗАРЧИМЛАХ 1. зарчимтай болгох; 2. зарчим баримтлах.

ЗАРЧИМЛУУЛАХ 1. зарчимлахын үйлдүүлэх хэв; 2. зарчимлагдах.

ЗАРЧИМТ зарчим журам бүхий; *зарчимт шүүмжлэл; зарчимт явдал; зарчимт санал.*

ЗАРЧИМТАЙ зарчим бүхий, журамтай, дэглэмтэй, зүй ёсонд нийлэмжтэй; *зарчимтай хүн.*

ЗАРЧИМЧ зарчим баримтлагч, зарчимтай.

ЗАСАА хүн амьтны им; *бухын засаа; хурганы засаа;* төмс ч гэдэг.

ЗАСАГ I 1. улсын байгуулалтын захирч удирдах хэлбэр, дээд газар; **нам засаг, засаг төр, засаг цааз** х о р ш . ; *ардын засаг; Зөвлөлт засаг; нам засгийн бодлого; хөрөнгөтний засаг;* 2. ямар нэгэн юмыг засч сайжруулах буюу мөрдөн журамлах тухайн арга явууллага; *засаг заслал; цэргийн засаг; эдийн засаг;* **засгийн газар** (улсын төрийн гүйцэтгэх төв байгууллага; *засгийн газрын шийдвэр);* **улс төрийн эдийн засгийн ухаан** (янз бүрийн нийгэмлэгийн үйлдвэрлэлийн арга нөхцөл хийгээд үйлдвэрийн бүтээгдэхүүнээ хэрхэн хувиарлан солилцож буйг судлах шинжлэх ухаан); **засаг захиргаа** (засгийн цааз хуулийг барьж олныг баримтлан захирах газар; *орон нутгийн засаг захиргаа);* **засаг заслал** (засгийн захирах тушаах арга хэмжээ); **эдийн засаг** (нийгэмлэгт ноёрхож байгаа үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэх **хүчний хөгжлийн** тухайн шатанд тохирч бий үйлдвэрлэлийн харьцааны цогц).

ЗАСАГ II х у у ч и р с а н албат ардыг эзэрхэн захирагч; *хушууны засаг.*

ЗАСАГГҮЙ захирч баримтлах газаргүй.

ЗАСАГДАХ засахын үйлдэгдэх хэв.

ЗАСАГЛАХ 1. баримтлан захирах; 2. шийтгэх, цээрлүүлэх.

ЗАСАГТАЙ засаг бүхий; *ардчилсан засагтай.*

ЗАСАГЧ I засгийн эрх баригч.

ЗАСАГЧ II юмыг сэлбэн засах хүн; *үс засагч; дугуй засагч.*

ЗАСАЛ I гоёлгын чимэг; **чимэг засал** х о р ш . .

ЗАСАЛ II сувилгаа, арчилгаа; *эм уугаад засал авч байна;* **мэс засал** (мэсээр хагалж огтлох аргаар эмчлэх эмнэлгийн нэгэн зүйл салбар; *мэс засал хийлгэх*).

ЗАСАЛТ засах үйлийн нэр.

ЗАСАЛЧ засал хийгч; *мэс засалч.*

ЗАСАМЖЛАГДАХ засамжлахын үйлдэгдэх хэв.

ЗАСАМЖЛАХ ямар нэгэн юмны гажиг, алдааг засах, арилгах.

ЗАСАМЖЛУУЛАХ засамжлахын үйлдүүлэх хэв.

ЗАСАХ I 1. нийлэмжгүй буюу **алдаа дутагдалтай** зүйлийг зохируулах, нэмэх, хасах зэргээр залруулах; *бичгийн алдаа засах; зохиол найруулгыг засах; алдаа дутагдлыг арилгаж засах;* 2. эвдэрсэн, гэмтсэн, хуучирсан зүйлийг шинэтгэх, сэлбэх, өөрчлөх; *орон сууц засах; ширээ сандал засах; хаалга цонх засах;* 3. юмыг санал зорилгод нийлүүлэн тохируулах; *маргаан тэмцлийг найралдуулан засах; зөрүү сондгойг эвлүүлэн засах;* **ор засах** (ороо унтахад бэлэн болгож зэхэх); **байшин засах** (а. байшин сав шинэтгэн сэлбэх; б. байшин савны дотоодыг тохируулан төвхнүүлэх); **ширээ засах** (идэх хоол зуушийг ширээнд өрж зэхэж бэлтгэх); **тал засах** (бусдыг биедээ татахын тул долигонох); **бөх засах** (барилдах бөхийг дагаж харгалзан барилдуулах); **үс засах** (гэзэг үс янзлах); **буурь засах, бууц засах** (а. гэр барих газрыг тохируулан янзлах; б. малын хот хэвтрийг янзлах); **гэр засах** (а. гэрийн модыг сэлбэх, шинэтгэх; б. гэрийн хэв хэлбэрийг засч барих); **явдлаа засах** (гажуу буруу үйл ажлаа засах); **санаагаа засах** (бу-

руу муу санаагаа орхих); **үүр засах** (шувуу мэтийн амьтад байр сууц барих); **биеэ засах** (а. биеийн өвчин эмгэгийг сувилах; б. биеэ цэвэр үзэмжтэй, аятай авч явах; в. өтгөн шингэн мөр үзэх).

ЗАСАХ II тэжээврийн амьтныг агтлах; *хурга засах; даага засах; бух засах; нохой засах.*

ЗАСАХ III биед арчлагаа сувилгаа хийх; *өвчнийг засах; архаг хуучнаа засах.*

ЗАСАХ IV: бие засах өтгөн шингэн мөр үзэх; *бие засах газар.*

ЗАСВАР 1. аливаа юмны эвдэрч элэгдсэнийг сэлбэх, шинэтгэх; *байшин засвар; ээлжийн засвар;* 2. аливаа засдаг үг; 3. юманд хийсэн заслага.

ЗАСВАРЛАГДАХ засварлахын үйлдэгдэх хэв.

ЗАСВАРЛАХ 1. засвар хийх; 2. гоёчлон засдаглах.

ЗАСВАРЛУУЛАХ 1. засварлахын үйлдүүлэх хэв; 2. засварлагдах.

ЗАСВАРТАЙ засвар бүхий.

ЗАСДАГ үнэн бусаар хуурмаглах, мэхлэх зан ааш; *элдвийн засдаг үг хэрэггүй.*

ЗАСДАГЛАХ 1. зориуд худал ташаагаар мэхлэх ааш зан гаргах; *муу бурууг нуун далдалж засдаглах; сайны хувийг хэтрүүлэх магтаж засдаглах; хуурмагаар засварлан засдаглаж аашлах;* 2. юмыг янз байдал оруулан засах.

ЗАСЛАГ: заслаг жүрж у р г а м а л амтат жүржийн адил болоод жижигхэн, амт хүчтэйхэн, жүржлэгийн адил сондуутай, үнэрлэвэл чаргагдсан хийг сарниулна.

ЗАСЛАГА засал засвар; *заслагатай, заслагагүй.*

ЗАСЛАХ юмыг олноороо буюу зэрэг зэргээр засах ба нэг юмыг байн байн буюу дахин дахин засах.

ЗАСМАГЛАХ засдаг зан гаргах.

ЗАСМАЛ ямар нэгэн засч хийсэн юм; *засмал зам; засмал уул; засмал чулуу; засмал зүлэг;* **засмал зам** (аливаа замыг шороо чулуу зэргээр засамжлан дагтаршуулж тэгш болгосон зам, цардсан цардаагүй хоёр зүйл бий).

ЗАСРАХ 1. засах засамжлах үйлийг биедээ дааж авах буюу өөрөө засагдаж сайжрах; *энэ хүний засрах эсэхий нь харъя; тэр засрах төлөв оржээ;* 2. муу муухай байдал нь дээртэх сэйжрах; **өнгө засрах** (юмны өнгө зүс үзэмж сайжрах); **яс чанар засрах** (урьдахаас дээр сайн болох); **өвчин засрах** (өвчин эдгэрэх төлөв орох); **ногоо засрах** (ногооны ургац дээшлэх); **бие засрах** (дорой байдал дээрдэх); **тэнгэр засрах** (салхи шуурга тогтох, үүл бороо арилж цэлмэх).

ЗАСРАШГҮЙ засрах шинж төлөв байхгүй.

ЗАСУУЛ бөх барилдуулахад дагаж зааварлах хүн, засуулч ч гэнэ.

ЗАСУУЛАХ 1. засахын үйлдүүлэх хэв; 2. засагдах.

ЗАСУУР засвар.

ЗАСЦАГААХ юмыг бэлтгэн төхөөрөх, засамжлах; *ширээ засцагаах; хувцсаа засцагаах.*

ЗАХ I 1. юмны хөвөө, ирмэг, хязгаар; **эн зах, зах ирмэг, зах хязгаар** х о р ш.; *даавууны* зах; *торгоны зах; номын зах; ширээний зах; нутгийн зах; тарианы газрын захаар явж байв;* 2. хувцас хунарын заам буюу тусгай хийсэн зүйл; *дээлийн зах; өмдний зах;* **зах заам** х о р ш.; ☆ **зах хязгааргүй** (хэмжээгүй; *зах хязгааргүй хол газар; зах хязгааргүй олон);* **захаас аван** (элбэг тохиолдол; *тийм явдал захаас аван дайралдана*); **захын цамх** (нутгийн хилийн тэмдэг болгож тавьсан тэмдэгт чулуу буюу овоо).

ЗАХ II анх хийгдсэн энгээр буюу бүхэл толгойгоор бараа; *зах торго; зах даавуу; зах бараа;*

ЗАХ III олон хүний цугларч харилцан худалдаалах газар; *барааны зах; өвс түлээний зах;* **зах зээл** х о р ш..

ЗАХДАХ хэтэрхий захад гарах.

ЗАХДУУ зах орчимд.

ЗАХДУУЛАХ захдахын үйлдүүлэх хэв.

ЗАХДУУХАН нилээд захдуу, баахан захдуу.

ЗАХИА 1. хүмүүсийн хоорондоо харилцаж илгээх бичиг захидал; **захиа захидал** х о р ш.; *захиа явуулах; захиа авах;* 2. бусдаар юм хүргүүлэх авахуулах буюу эсвэл нэвтрүүлсэн үг мэдээ: **хэл захиа** х о р ш.; 3. хүндэтгэвэл зохих хүний хэлсэн үг, сургаал; **захиа занаа захиа зарлиг** х о р ш.; 4. захисан захиалсан юм; *захиа хоол; захиа хувцас.*

ЗАХИАЛАГЧ захиалах этгээд; *захиалагч байгууллага.*

ЗАХИАЛАХ 1. захиа захидал илгээх; 2. бусдад үг захих буюу юм хум захих; 3. **ямар нэгэн** юмыг захиж бэлтгүүлэх; *хувцас захиалах; хоол захиалах.*

ЗАХИАЛГА захих үйлийн нэр; *захиалга өгөх; захиалга авах.*

ЗАХИАЛГАТ захиалгатай; *захиалгат бараа.*

ЗАХИАЛГАТАЙ захиалга бүхий.

ЗАХИАЛУУЛАХ захиалахын үйлдүүлэх хэв.

ЗАХИГЧ захисан этгээд.

ЗАХИДАЛ албан газар буюу хүмүүсийн хоорондын харилцааны захиа; *албан захидал; хувийн захидал;* **ил захидлын хуудас** (шуудангийн байгууллагаас тусгайлан зураг чимэглэлтэй үйлдсэн хуудас); **ил захидал** (тусгай хуудсанд бичиж дугтуйгүй илгээж харилцах захидал).

ЗАХИРАГДАХ захирахын үйлдэгдэх хэв, захируулах.

ЗАХИРАГЧ Дайчин улсын үеийн тамгын дөрвөн түшмэлийн нэг, иргэний захиргааны хэргийг эрхэлсэн албан тушаал; *хушуу захирагч; тамгын захирагч.*

ЗАХИРАЛ жижиг хэсэг бүлэг газар буюу сургуулийн хэргийг эрхлэн захирах хүний албан тушаалын нэр; *харуулын захирал; өртөөний захирал; сургуулийн захирал.*

ЗАХИРАМЖ тушаалын нэг хэлбэр.

ЗАХИРАХ дур харгалзахгүй тушааж даалгах, дагуулах.

ЗАХИРГАА захирах үйлийн нэр, захирах газар, **засаг захиргаа** х о р ш.; *захиргаа аж ахуйн хэлтэс; захиргааны зардал.*

ЗАХИРГААГҮЙ захирах газаргүй захирагддаггүй; *засаг захиргаагүй.*

ЗАХИРГААТАЙ захиргаа бүхий; *захирагддаг.*

ЗАХИРГАХ захируулах.

ЗАХИРЛАГА тамга тэмдэг; *өртөөний захирлага;* **тамга захирлага** х о р ш..

ЗАХИРУУЛАХ 1. захирахыг үйлдүүлэх хэв; 2. захирагдах.

ЗАХИУЛАХ захихын үйлдүүлэх хэв.

ЗАХИХ 1. хүнд захиа өгөх; 2. аль нэгэн хэргийг эрхбиш гүйцэтгүүлэхээр дурьдан сануулах; *эцэг нь хүүдээ эрдэм сайн сур гэж захив;* 3. захиалах; *сонин захих.*

ЗАХЛАХ 1. **эд юманд зах** хийх; *дэвсгэр ширдэг захлах; хувцас хунар захлах;* 2. нуур далайн ус **захаараа** хөлдөж эхлэх; *нуур захлах; гол захлах;* 3. захаар нь орших; *захад нь гарах; мал захлах; хонь захлах;* 4. хүн амьтны тулгууртайгаар бэхлэн гишгэх; *тэрэгний морь захлан зогсов.*

ЗАХЛУУЛАХ захлахын үйлдүүлэх хэв.

ЗАХУУР захаар; *ус мөрний захуур; хот суурины захуур.*

ЗАХЧИН Монголын Торгууд аймгийн нэгэн хэсэг; урьдын цаг Торгууд аймаг; Зүүнгар улс гэж байх үед улсын зах хязгаарыг сахих цэргийн ардыг захчин гэж нэрийдэж явснаас **тийнхүү нэршжээ.**

ЗАШИН: зашин дэглий а м ь т а н нэг зүйл дэглий шувуу, хавар намрын улиралд энэ шувуу нисч **өнгөрвөл зүсэрнэ гэдэг.**

ЗАЯ зав.

ЗАЯА хувьд оногдсон зол, учрал, тохиол; *хүний хувь заяа; сайн заяа; заяа муут;* **хувь заяа** х о р ш.; *заяаны мэнгэ; заяаны нөхөр Алтансантай жаргалынхаа замыг холбожээ хөө* (ардын дуу); **амар заяа үзүүлэхгүй** (тайван байлгахгүй); **заяа мэдэг** (хувь аз мэдүгэй).

ЗАЯАГҮЙ хувьгүй, азгүй.

ЗАЯАДАХ юмыг хүлээж чадахгүй буюу хүчин хүрэлцэхгүй самгардан тэвдөх.

ЗАЯАЛГАХ заяахын үйлдүүлэх хэв.

ЗАЯАТАЙ заяа, бүхий, хувьтай, азтай; *сөнөх заяатай; заяатай хүү; заяатай гарав.*

ЗАЯАХ хувь золоор учирч оногдох; *үр заяах; хоол заяах.*

ЗАЯАХАЙ у р г а м а л хөнгөн чанарын модлог ургамал, навч зүрхэн хэлбэртэй, жимсний өнгө шаравтар, эмнэлэгт хэрэглэнэ, гандгаарч гэнэ.

ЗАЯДАХ нэг үнээнд хэд хэдэн тугал хөхүүлж тэдгээр тугалын эхийг хайдагшуулан саах.

ЗАЯДУУЛАХ заядахын үйлдүүлэх хэв.

ЗЕНИТ онгоц зэрэг агаарын юм буудах буу; *зенит их буу.*

ЗОВЛОГО 1. мал гөрөөсний ихэд алжаасан буюу туранхайлан үхсэний амт шимгүй болсон мах; 2. **туранхай эцэнхий мах;** *хонины зовлого;*

ямааны зовлого; **улаан зовлого** (өөхгүй туранхай мах).

ЗОВЛОГОДОХ хэтэрхий зовлого болох.

ЗОВЛОГОРОХ зовлого болох.

ЗОВЛОГОШИХ зовлого шинжтэй болох.

ЗОВЛОН 1. ямар нэгэн шалтгаанаар тохиолдсон бие, сэтгэлийн зүдүүр шаналгаа; *биеийн зовлонгоос сэтгэлийн зовлон хэцүү;* **гаслан зовлон, зовлон гамшиг, зовлон зүдүүр** х о р ш.; 2. хүнд хүчир буюу төвөг бэрхшээл ихтэй үйл; *зовлонтой ааштай хүн; зовлонтой ажил,*

ЗОВЛОНГҮЙ 1. амар жаргалантай; 2. амар хялбар, бэрхшээл төвөггүй; *зовлонгүй бүтээ.*

ЗОВЛОНТ зовлонтой; **зовлонт нуруу, асуух нуруу** (ууц нуруу хоёрын уулзар нуруу).

ЗОВЛОНТОЙ 1. зовлон тохиолдсон нь; 2. хал хашрал ихтэй; *зовлонтой хэрэг байна даа.*

ЗОВНИЛ зовох үйлийн нэр.

ЗОВНИУЛАХ зовнихын үйлдүүлэх хэв.

ЗОВНИХ энэлэн шаналах; *сэтгэл зовних.*

ЗОВОЛ зовлон тохиолдсон нь; **үхэл зовол, хагацал зовол** х о р ш..

ЗОВОМТГОЙ зовох зантай, ичимтгий.

ЗОВОМХОЙ зовомтгой.

ЗОВИНГ 1. яданги, зүдэнгэ; *сэтгэл зовонгоо,* 2. халшрамтгай.

ЗОВОНГИДУУ зовонги байдалтай.

ЗОВООЛГОХ 1. зовоохын үйлдүүлэх хэв; 2. зовоолготдох.

ЗОВООХ 1. зовохын үйлдүүлэх хэв, зовоход хүргүүлэх; 2. зовоогдох.

ЗОВОРЬ шаналгаа ихтэй, зүдүүр ихтэй; *их л зоворьтой бололтой байна билээ;* **зоворь өвчин** (их л эвэршилтэй өвчин).

ЗОВОРИЛОХ ихэд эвэршилтэйгээр өвдөх.

ЗОВОХ аливаа амьтны бие зүдэж чилэх ба сэтгэл зовниж амаргүй болох; *тэр хүүхдийг юм сурахгүй гэж би зовох юм.*

ЗОВУУРИЛАХ өвчин зовлон **хүнддэж их л** зүдрэх; *өвчиндөө зовуурилах.*

ЗОВУУРЬ ямар нэгэн учирт бие сэтгэл энэлэн зовох; **зовуурь зүдүүр** (ядран доройтож шаналах).

ЗОВУУРЬТАЙ зовуурь бүхий, шаналгаатай.

ЗОВХИ угтаа хүн амьтны нүдний аньсгын гадаад өнцгийн нэр; одоо нүдний дээд доод аньсгын нэр; *дээд доод зовхи;* **зовхи татах** (нүдний зовхи чицав татав хийх).

ЗОВХИС дөрвөн зүгийн хоорондох завсар; *дөрвөн зовхис; дөрвөн зүг, найман зовхис.*

ЗОГ: зог тусах амьтны явж хөдөлж байснаа гэнэт больж давхийн зогсох, мөн гэнэт зайлсхийх; **зог хийх** (а. явж байсан морь малын гэнэт зогсох: б. хүний ажлаа түр зогсож амрах).

ЗОГДОР тэмээний хүзүү хоолойд ургасан урт хялгасан үс; **зогдор хөдөлгөх** (тэмээгээр зөөлөн гүйлгэн явах).

ЗОГДОРЛОХ тэмээний зогдрыг хайчлан авах.

ЗОГДОРЛУУЛАХ зогдорлохын үйлдүүлэх хэв.

ЗОГОГХИЙХ зугаацаар явах.

ЗОГСГОЛЗОХ 1. бага хүүхдийн сая тэнцэн босох; 2. үйл ажлын түр зогсох, саатасхийх; *ажил зогсголзох; бороо зогсголзох.*

ЗОГСЗОНОХ түр зогсох, сэгхийх, завсарлах.

ЗОГСЗОНУУЛАХ зогсзонохын үйлдүүлэх хэв.

ЗОГСОЛ тогтнол.

ЗОГСОЛГҮЙ тасалдаж завсарлалгүй үргэлжлэх нь; *бороо зогсолгүй орох.*

ЗОГСОЛТ зогсох үйлийн нэр, зогссон, завсарласан нь.

ЗОГСОЛТГҮЙ тасралтгүй, үргэлжид.

ЗОГСОЛТТОЙ зогсолт бүхий.

ЗОГСОНГИ үйл ажлын удаашралтай, явц муутай; *зогсонги байдал.*

ЗОГСОНГИДУУ зогсонги байдалтай.

ЗОГСОО 1. босоо; **босоо зогсоо** х о р ш.; *зогсоо хүний хиртэй;* 2. үргэлж, дараа дараагаар; *зогсоо зайгүй цувах.*

ЗОГСООГООР үргэлжид; *зогсоогоор тохиолдоно; зогсоогоор горилон хүлээнэ.*

ЗОГСООЛ 1. ямар нэгэн юмны тогтмол зогсох газар; *галт тэрэгний зогсоол; онгоцны зогсоол; автобусны зогсоол;* 2. адууг цуглуулж түр амруулах газар; *адууны зогсоол;* 3. гүйцсэн, ханасан; *эрэг зогсоолдоо хүрчээ; зоогны сав зогсоолдоо хүрчээ.*

ЗОГСООЛГОХ зогсохын үйлдүүлэх хэв, зогсоход хүргүүлэх.

ЗОГСООХ зогсохын үйлдүүлэх хэв, зогсоход хүргүүлэх; *тэрэг зогсоох.*

ЗОГСОХ ямар нэг хөдөлгөөнтэй юм хөдлөхгүй болох; 1. амьтны хөл дээрээ хөдөлгөөнгүй байх; *босоо зогсох; номхон зогсох;* 2. юмны хөдөлгөөн намжих, саарах, болих, тогтнох; *салхи зогсох; зорчихыг зогсох; бороо зогсох;* 3. ажил үйл түр буюу бүрмөсөн төгсөх, болих; *миний ажил зогссон;* 4. эцэх, цуцах; *миний морь эцээд зогсчихов;* 5. эвдрэх, хэмхрэх; *машина гэмтээд зогсов;* 6. нөхцөл бүрдэхгүйгээс ажил тасалдах; *материал тасраад үйлдвэр зогсов.*

ЗОГСУУЛАХ зогсоход хүргүүлэх, зогсоох.

ЗОГТУСАХ зог тусах; *унжсан морь минь зогтусахад би арай чарай тогтож билээ.*

ЗОГХИЙХ 1. зог хийх; 2. түр амсхийх.

ЗОГЬСОХ хүний дээш гүйх хий буруутан боогдож дотор долгилон, байн байн хоолой эхэр татан дуугарах.

ЗОГЬСУУЛАХ зогьсохын үйлдүүлэх хэв.

ЗОДОГ I барилдахад өмсөх цээжмэг хувцас, цамцны адил бөгөөд энгэргүй, баахан чухал давч; **зодог тайлах** (а. өмссөн зодгийг тайлах; б. барилдахгүй болох).

ЗОДОГ II харгай модны зузаан холтос; *модны зодог.*

ЗОДОГЛОХ 1. барилдах бөхчүүд зодгоо өмсөх; 2. ажил хийхэд биеэ бэлэн болгох.

ЗОДОГЛУУЛАХ зодоглохын үйлдүүлэх хэв.

ЗОДОЙ а м ь т а н хэвэл том, толгой жижиг бөгөөд ам улаан, өнгө мөнгөн цагаан нэг зүйл загас.

ЗОДОЛДООН харилцан зодолдох үйлийн нэр.

ЗОДОЛДООЧ зодолдоход сурамгай.

ЗОДОЛДОХ зодохын үйлдэлдэх хэв, харилцан зодох.

ЗОДОЛДУУЛАХ зодолдохын үйлдүүлэх хэв;

ЗОДОН ороонго зэлийн ширхгээр нэхсэн нэгэн зүйл эд.

ЗОДООН зодолдсон нь; **зодоон цохион** х о р ш.; *зодоон гаргах; зодоон хийх.*

ЗОДООНЧ зодолдооч.

ЗОДООЧ зодоонч.

ЗОДОХ жанчих, дэлдэх; **зодох жанчих** х о р ш.

ЗОДУУЛАХ 1. зодохын үйлдүүлэх хэв; 2. зодогдох.

ЗОДУУР зодох хэрэгсэл; **зодуур нүдүүр** х о р ш.

ЗОЖИГ гажууд, зөрүүд; олноос салангид; *зожиг зантай; зожиг ямаа.*

ЗОЖИР у р г а м а л иш шулуун, навч хулс модны навчтай адил цайвар ногоон өнгөтэй, гурав гурваар эсэргүүцэн ургадаг, эмийн зүйлд хэрэглэнэ.

ЗОЛ аз завшаан, ямар нэгэн сайн тохиол учралдах буюу мууч учралаас гэтлэх хувь; *зол дайрав; золтой гарав; миний зол болов;* **зол заяа, заяа зол** х о р ш.; **зол сайн** (аливаа хүн, алс хол замд удаан явахад саадгүй сайн); **зол эрэх** (завшаан эрэх).

ЗОЛБИГНОХ хүн амьтны золбин болох.

ЗОЛБИН гэрийн тэжээвэр амьтны эзэнгүй алдуул завхуул болох буюу зэрлэгших; *золбин мал; золбин нохой.*

ЗОЛБИНТОХ золбин байдал гаргах, золбин болж тэнүүчлэх.

ЗОЛБИРОХ золбин болох.

ЗОЛБИРУУЛАХ золбирохын үйлдүүлэх хэв, золбироход хүргүүлэх.

ЗОЛБИШРОХ золбин шинжтэй болох.

ЗОЛБИШРУУЛАХ золбишрохын үйлдүүлэх хэв.

ЗОЛГОЛГО харилцан **золгох нь**.

ЗОЛГОЛДОХ золгохын үйлдэлдэх хэв.

ЗОЛГОЛДУУЛАХ **золголдохын** үйлдүүлэх хэв.

ЗОЛГОЛТ золгох үйлийн нэр.

ЗОЛГОХ 1. Монголчууд шинэ жил гараад танил хүмүүстэйгээ анх **удаа уулзахад харилцан** гар зөрүүлэн ёсолж **мэндчилэх**; 2. хүний харилцан уулзах, учрах; 3. **барилдах бөхчүүдийн** харилцан барилцаж **авах**.

ЗОЛГУУЛАХ золгохын **үйлдүүлэх хэв**.

ЗОЛГҮЙ 1. азгүй, **хий морьгүй, завшаангүй**; *золгүй хэрэг болов;* 2. мөсгүй, чанаргүй, шинжгүй; *золгүй зан гаргах; золгүй эд.*

ЗОЛИГ золио, золиос; **золигт гаргах** (золиосонд гаргах зан үйл).

ЗОЛИГЛОХ золионд гаргах.

ЗОЛИГҮЙ хүний явдал ёс зүйд нийлэлцэхгүй буюу цог чадваргүй үхээнц дорой, **хий морьгүй**.

ЗОЛИО золихын учир **өгөх гаргах эд юм**.

ЗОЛИОДОС золионд **өгөх эд юм**; *золиосонд явах.*

ЗОЛИОС золионы юм.

ЗОЛИУЛАХ золихын үйлдүүлэх хэв, **золиход** хүргүүлэх.

ЗОЛИХ данжлам зээлсэн өрийг төлж уул данжилсан юмыг эгүүлэн авах, ялд харгуулан эд мөнгө өгөхийн зэрэг нэгэн юмыг өөр юмаар төлөөлүүлэн солих.

ЗОМГОЛ юмны үлтэрч **хэмхэрч няцарснаас** гарсан жижиг хэсэг юм; *модны зомгол; цаасны зомгол; зомгол түүх; зомгол болгох.*

ЗОМГОЛДОХ хэтэрхий зомгол болох.

ЗОМГОЛЛОХ зомгол болох.

ЗОМГОЛРОХ зомгол болох.

ЗОНА бүс.

ЗОНДОР тосгоны дарга.

ЗОҢХИ олонхи, ихэнх, **дийлэнх**; **олонхи зоңхи, ихэнх зонхи** х о р ш . .

ЗОНХИЛОХ ихэнх, дийлэнх хувийг эзлэх, гол суурь эзлэх.

ЗОО I 1. хүн амьтны нурууны журмын ба нурууны хоёр хажуугийн зураа; 2. аливаа үслэг ан амьтны арьс ширний нурууны орчин газар; *үнэгний арьсны зоо;* 3. **баахан** уртлаг бөгөөд аюу гүдгэр газар; *уулын зоо; нуруу зоо;* **зоо авах** (хүний ууц бэлхүүсний тус мах шөрмөсөнд цустай хий орж хөдлөх алхах гишгэхэд зовуурилан өвдөх ба адуу тэмээний зэрэг малын харцагын дотоодод цус хий орж хойт хөл орогнитон доголох өвчний нэр); **зоо хөдлөх** (зоо авах): **зоо мах** (сээр нурууны хоёр талын зураа мах).

ЗОО: зоо-мал эмнэлэг зоотехник-мал эмнэлэг; *зоо-мал эмнэлгийн анхны мэдэгдэхүүн.*

ЗООГ 1. эрхэмлэн хүндэтгэвэл зохих хүний идээ ундаа; *зоог барих;* **зоогийн газар** (хөнгөн зууш, ундаа зарах газар); 2. зугаа; **зоог зугаа** х о р ш . ;

ЗООГДОХ зоохын үйлдэгдэх хэв; *дүгүй шаварт зоогдох.*

ЗООГЛОХ хүндэтгэвэл зохих хүний идэх уух; *хоол зооглох; цай зооглох.*

ЗООГЛУУЛАХ зооглохын үйлдүүлэх хэв.

ЗООГХИЙХ 1. зугаахийх, зугаацах; 2. үйл ажилд үл ялих зүйлээр шалтаглан хойш суух; *ааг зоогхийх.*

ЗООДОЙ зодой, нэгэн зүйл загас.

ЗООЛГОХ зоохын үйлдүүлэх хэв.

ЗООЛГУУЛАХ зоолгохын үйлдүүлэх хэв.

ЗООЛДОХ арьс ширний зоо дагуу газрыг авах.

ЗООЛДУУЛАХ зоолдохын үйлдүүлэх хэв.

ЗООЛОГИ амьтны судлал.

ЗООЛОГИЧ амьтны судлалч.

ЗООЛОХ I 1. зоолдох; *арьс зоолох;* 2. зоо газраар явах.

ЗООЛОХ II нохой, муурын зэрэг араатны хоол тэжээлээр бие таргалан өнгө жавхлан сайжрах.

ЗООМОЛ зоож хийсэн юм.

ЗООНГИ зоолттой.

ЗООПАРК амьтны хүрээлэн.

ЗООРИЛОХ юмыг зоорьд агуулах; *сүү зоорилох.*

ЗООРИЛУУЛАХ зоорилохын үйлдүүлэх хэв.

ЗООРЬ 1. байшин гэрийн дор буюу энгийн газар алин боловч газрыг ухаж юм хум хадгалахаар бэлтгэсэн сав буюу нүхэн сав; *ногооны зоорь; хүйтэн зоорь;* 2. хөрөнгө; **хөрөнгө зоорь** х о р ш . .

ЗООС металлаар хийсэн мөнгөн тэмдэгт; *алтан зоос; мөнгөн зоос; хүрэл зоос;* **мөнгө**

зоос хорш.; **сохор зоосны үнэгүй** (улаан мөнгөний үнэгүй); **зоос цэлцдий амьтан** (өвчүүндээ зоос мэт хар цагаан толботой нэгэн зүйл бялзуухай); **зоос цэцэг ургамал** (зоос мэт хүйстэй, өнгө шар нэгэн зүйл цэцэг).

ЗООТЕХНИК хөдөө аж ахуйн амьтдыг үржүүлэн өсгөх тухай шинжлэх ухаан; *зоотехникийн анхны мэдэгдэхүүн.*

ЗООТЕХНИКЧ зоотехникийн шинжлэх ухаанд мэрэгжсэн хүн.

ЗООХ юмыг юманд босгон суулгаж, бэхлэн тогтоох; *газарт зоох; мод хаданд зоох; шон мод зоох; сүхээ модонд зоох.*

ЗОР аз, зол, ан гөрөө хийх зэрэгт учрах тохиох хувь; *зортой сайн гөрөөчин; зор сайтай буу;* **зор эзэрхэх** (хүний ганцаараа эзэрхэх); **зор эзэрхүүлэхгүй** (адил тушаалын хүнийг тоохгүй санааны дураар эзэрхэж явах).

ЗОРГИЛГОХ 1. хүний өндөр дуугаар хашгирах; 2. хог тоосыг дэгдүүлэн шүүрдэх, гүвэх, сэгсрэх.

ЗОРГО (Н) дураар, таваар, чөлөөтэй; *зоргоороо аашлах; зоргоороо тэнэх; зоргоороо байх.*

ЗОРГОДОС I ургамал янз буудайн мөхлөгтэй адил, амт халуувтар, үнэр анхилам нэгэн зүйл ногоо, гоньд ч гэнэ.

ЗОРГОДОС II юмыг зорох харуулдахад оглогдон гарах зомгол; *модны зоргодос; төмрийн зоргодос.*

ЗОРГОЛ нэг настай буга.

ЗОРГҮЙ азгүй, золгүй.

ЗОРДОС 1. юмыг зороход гарсан үүрмэг; 2. зоргодос.

ЗОРДОСЛОХ зордос болгох.

ЗОРИГ I 1. амьтны үйл ажилд хичээх чармайх хувь; *мохошгүй чин зориг; хэлбэрэхгүй бат зориг;* 2. дур хүсэл; *дур зориг; хүсэл зориг; зүрх зориг; дур зоригийн хээлтүүлэг;* **зориг орох, зориг бадрах** (ямар нэгэн үйл хэрэгт дуршил нь нэмэгдэж хичээн зүтгэх); **зориг мэдэх** (хүн өөрийн дураар зэрэг хирээс хэтрэмгийлэн хэв зүйгээс ангид аашлах); **зориг мохох, зориг алдах, зориг шантрах** (үйл хэрэгт дуршил нь муудаж, хичээл зүтгэл хасагдах, дордох); **зоригийг тэжээх** (урмыг тэжээх).

ЗОРИГ II тооны нэр, арван цадчин.

ЗОРИГГҮЙ сэтгэлийн хичээх чиггүй, шантрамхай, мохоо.

ЗОРИГГҮЙДЭХ зориггүйн учир тохиромжгүй болох.

ЗОРИГЖИХ зориг нь улам нэмэгдэх, зориг орох.

ЗОРИГЖУУЛАГЧ зоригийг хөгжөөхөд нөхцөл болох зүйл.

ЗОРИГЖУУЛАХ зоригжихын үйлдүүлэх хэв, зоригжиход хүргүүлэх.

ЗОРИГЛОХ зориг гаргаж зүтгэх.

ЗОРИГЛУУЛАХ зориглохын үйлдүүлэх хэв, зориглоход хүргүүлэх.

ЗОРИГООР өөрийн дур мэдлээр; *дур зоригоороо явах.*

ЗОРИГТ зориг бий юм; *чин зоригт.*

ЗОРИГТОЙ зориг ихтэй; биеэ даасан байдалтай, шийдэмгий зантай; *зоригтой тэмцэх; зоригтой дэвшүүлэх.*

ЗОРИГШИХ зориг нэмэгдэх шинжтэй болох.

ЗОРИЛГО алсын ирээдүйд хүрэх гэсэн эрмэлзэл бодлого; *эв хамтын ёст байдалд хүрэх зорилго; зорилго тавих.*

ЗОРИЛТ ойрын ирээдүйд гүйцэтгэхээр шийдвэрлэсэн бодлого; *үйлдвэрийг хөгжүүлэх явдал бол манай одоогийн зорилт мөн.*

ЗОРИМГОЙ зоригтой, шийдэмгий.

ЗОРИМГОЙДУУ зоримгой байдалтай, шийдэмгийдүү.

ЗОРИМГОЙХОН баахан зоримгой, арай зоримгой.

ЗОРИМОГ хүний санасан хүссэн хэрэгтээ буцах няцахгүй зоримтгой чанар; *зоримог хүн;* 2. мугуйд зан байдал.

ЗОРИМОГДОХ хэтэрхий зоримог зан гаргах.

ЗОРИМОГЛОХ зоримог зан ааш гаргах.

ЗОРИМГООР зоримог зангаар аашлах; *зоримгоор давших.*

ЗОРИУД зорилготой, санаатай; *зориуд би хэлж байна; зориуд мдэгдье.*

ЗОРИУЛАГДАХ зориулахын үйлдэгдэх хэв; *хэрэгцээнд зориулагдах; хоолонд зориулагдах.*

ЗОРИУЛАХ зорихын үйлдүүлэх хэв; *ойд зориулсан хурал.*

ЗОРИХ 1. ямар нэгэн үйл ажлыг эцэс туйлд нь хүрэхээр хичээх, чармайх; *сурахын төлөө*

зорих; жаргалантай амьдрахыг зорих; 2. нэг газраас нөгөө газраа хүрэхээр явах зорчих; *алс хэтийг зорих; орон нутагт зорих.*

ЗОРОХ ямар нэгэн зэвсгээр юмыг элэн харах; *мод зорох; тугалга зорж хийсэн эд.*

ЗОРТОЙ азтай, золбоотой.

ЗОРУУЛАХ зорохын үйлдүүлэх хэв.

ЗОРХ I сумны годил, хушуу шуумгай, таван нүүр нүдтэй, хойт этгээд бөөрөнхий нэгэн зүйл харвах зэвсэг.

ЗОРХ II ясаар хийсэн харвуулын сумны зэв.

ЗОРЧИГЧ зорчин явагч, жуулчлагч; *онгоцоор зорчигч.*

ЗОРЧИХ 1. бага хүүхдийн сая хөлд орж алхан төсөөлөх; 2. хүн амьтны ийш тийш явах; **явах зорчих** х о р ш . .

ЗОРЧУУЛАХ зорчихын үйлдүүлэх хэв.

ЗОС өгөршсөн төмрийн хүдрээс үүсэх бий болсон шороон будаг; *улаан зос; шар зос.*

ЗОСДОХ юмыг зосоор будах буюу тэмдэг тавих; *унийн мод зосдох; хонины нуруу зосдож тэмдэглэх.*

ЗОСДУУЛАХ 1. зосдохын үйлдүүлэх хэв; 2. зосдогдох.

ЗОСТОЙ 1. зос бүхий; 2. зос тэмдэгтэй; *нурууныхаа дээр зостой хонийг барьж аваарай.*

ЗОХИД нийцэж зохилдсон, аятай; *зохид өдөр; зохид ажил.*

ЗОХИДХОН нилээд зохид, аятайхан таарсан.

ЗОХИЛ нийцэж зохицсон нь; *зохил болох; зохил муутай.*

ЗОХИЛДОХ юмны нийлэлцэх нэгдэх буюу тохирох, бололцох; *санаа сэтгэл зохилдох; ажил явдал зохилдох; огт зохилдохгүй хэрэг.*

ЗОХИЛДУУЛАХ зохилдохын үйлдүүлэх хэв.

ЗОХИЛТОЙ зохистой, тохиромжтой, нийц нийлэмжтэй.

ЗОХИМЖ тохиромж, нийлэмж, таарамж, зохиромж; *зохимж муутай; зохимж сайтай.*

ЗОХИМЖГҮЙ тохиромжгүй, нийлэмжгүй, таарамжгүй; *над зохимжгүй санагдана.*

ЗОХИМЖТОЙ тохиромжтой, нийлэмжтэй, таарамжтай, зохистой; *зохимжтой сайхан харагдаж байна.*

ЗОХИОГДОХ зохиохын үйлдүүлэх хэв.

ЗОХИОГЧ юмыг зохиож бий болгосон, бүтээсэн хүн; *зохиогчийн өгүүлсэн нь...*

ЗОХИОЛ I аливаа зохиосон ном бичиг; **ном зохиол; бичиг зохиол** х о р ш .; *гүн ухааны зохиол; сонгодог зохиол;* **зохиолын түүвэр** (зохиогчийн зохиолоос түүж нийтлүүлсэн ном дэвтэр); **аман зохиол** (зохиосон тодорхой эзэнгүй бөгөөд ард олны дунд түгэн дэлгэрч, амаар улиран уламжлагдаж ирсэн зохиол); **уран зохиол** (хүн, юм, үйл явдлын дүр шинжийг үгээр илрүүлдэг нэг зүйл урлаг); **бичгийн зохиол** (бичсэн, барласан, хэвлэсэн ном, бичиг зэрэг зүйл); **утга зохиол** (а. бичгийн зохиол; б. уран зохиол).

ЗОХИОЛ II хувь заяа, учрал тохиол; **хувь зохиол** х о р ш .; *миний хувь зохиол ийм ажээ; хувь зохиол сайтай.*

ЗОХИОЛГОХ зохиохын үйлдүүлэх хэв, зохиоход хүргүүлэх.

ЗОХИОЛЧ ном бичиг зохиодог хүн; *уран зохиолч; түүхийн зохиолч; хүүхдийн зохиолч; кино зохиолч; зохиолчдын холбоо; зохиолчдын хороо; зохиолчдын их хурал.*

ЗОХИОМЖ зохиох төлөв, зохиосон байдал; *туужийн зохиомж.*

ЗОХИОМОЛ байгалийн биш, угийн биш, хиймэл; **зохиомол хээлтүүлэг** (хээлтүүлэгч малын үрийг авч хээлтэгч малд хиймэл аргаар хийх).

ЗОХИОХ 1. юмыг үүсгэх, төлөвлөх, тогтоох, хуваах, зохицуулах, зохион байгуулах; *үүсгэн зохиох; төлөвлөн зохиох; олон түмний ажил зохиох; зохион байгуулагч; зохион зааварлах хэлтэс; зохион бүтээх;* 2. бичиг зохиол үйлдэх, боловсруулах; *түүх шашдир зохиох; жүжгийн зохиол зохиох.*

ЗОХИРОЛ зохицон тохирох нь; *зохирол сайтай; зохирол муутай;* **зохирол эрэмбэ** (нэг буюу хэд хэдэн нийлцийн дотор хөгжмийн эгшгийн өгсөх буюу уруудах эрэмбэ).

ЗОХИРОМЖ зохимж, нийлэмж.

ЗОХИРОХ 1. муудалцсан хүмүүсийн харилцан сайн болох, эвлэрэх; *найрамдан зохирох; эвлэрэн зохирох;* 2. аливаа юмны сайнд тог-

тох; *цаг улирал зохирох; тэнгэр зохирох;* 3. тохирох, таарах, зохицох.

ЗОХИРУУЛАХ зохирохын үйлдүүлэх хэв.

ЗОХИС 1. зүй; **зүй зохис х о р ш.**; *зохистой шийдвэр; зохистой арга;* 2. **юмны тухайн** байдалд зөв нийлүүлэх аяс; *зохисыг нь үзэж шийдвэрлэх; зүй зохисоор турших.*

ЗОХИСГҮЙ тохиромжгүй, зүйгүй, болломжгүй, бүтэмжгүй; *зохисгүй хэрэг бүү үйлд.*

ЗОХИСТ зохистой.

ЗОХИСТОЙ зүйтэй, зөвтэй, ёстой, таатай, нийлэмжтэй; *зохистой цаг; зохистой үйл.*

ЗОХИХ зүй ёсонд нийлэлцэх; *мөрдвөл зохих суртал; дагавал зохих явдал; зохих хугацаа; зохих арга хэмжээ авах;* 2. таарах, тохирох; *идээн ундаан зохих; хувцас хунар зохих;* 3. харьяа удирдах газар ба хүмүүс; *зохих газар; зохих удирдлага.*

ЗОХИХГҮЙ зүйд нийлэхгүй, тохирохгүй, зохицохгүй, шингэхгүй; *хоол зохихгүй болов.*

ЗОХИЦОЛ зохирол, тохирол, нийцэл, найрал.

ЗОХИЦОХ харилцан тааламжтай болох ба эдэх, найралдах; *санаа зохицох; явдал зохицох; сэтгэл зохицох; үйл зохицох.*

ЗОХИЦУУЛАГЧ зохицуулдаг этгээд.

ЗОХИЦУУЛАХ зохицохын үйлдүүлэх хэв, зохицоход хүргүүлэх.

ЗОЧИН 1. гаднаас ирсэн хүндэтгэвэл зохих хүн; **гийчин зочин** х о р ш.; *гадаадын зочин;* 2. харийн, бусдын.

ЗОЧИР гэв гэнэт, сочмог; цочир-ч гэнэ; *зочир үүртай; зочир зантай.*

ЗОЧИРДОХ хэтэрхий зочрын учир тохиромжгүй болох; *зочирдоод айраг их дуж чадсангүй; зочирдоод үг ч хэлж чадсангүй.*

ЗОЧИРДУУЛАХ зочирдохын үйлдүүлэх хэв.

ЗОЧИРХОГ 1. зочломтгой; 2. бэрхшээмтгий, хүнийрхүү байдалтай.

ЗОЧИРХОХ 1. аливаа үйл хэрэгт халширан бэрхшээх; 2. хүнийрхүү байдал гаргах; *та битгий зочирхоод бай.*

ЗОЧИРХУУ зочирхог.

ЗОЧИРХУУЛАХ зочирхохын үйлдүүлэх хэв.

ЗОЧЛОМГОЙ зочлох зантай, зочилдог зантай; *тэднийх их зочломгой айл шүү*

ЗОЧЛОМТГОЙ зочлох заншилтай, зочломтгой.

ЗОЧЛОХ 1. айлчлах; айлчлах зочлох х о р ш.; 2. хүнийг хүндэтгэн үзэж талархах, дайлах; *зочилж ирэх; зочлох тасалгаа; зочлох урилга.*

ЗОЧЛУУЛАХ 1. зочлохын үйлдүүлэх хэв; 2. зочлогдох.

ЗОЧМОГ түргэн, бачим, гэнэт; *зочмог үүртай хүн; зочмог хурдтай морь.*

ЗОЧМОГДОХ хэтэрхий зочмогийн учир тохиромжгүй болох; бачимдах.

ЗОЧМОГДУУЛАХ зочмогдохын үйлдүүлэх хэв.

ЗОЧМОГЛОХ сочмог байдал гаргах.

ЗОЧМОГРОХ зочмог болох.

ЗОЧМОД 1. зочдыг дайлах хүн; 2. зочид.

ЗӨВ аливаа юмны зүйтэй, зохистой; *зөв ёс; зөв журам; зөв үзэл;* **зөв зам** (а. олон салаа замаас зорьсон газарт очих зам; б. үйл хэргийн дотроос тохирох, тэнхцэх нь; *чиний ганц зөв зам бол сургуульд орох явдал мөн*); **зөв санаа** (өөр бусдад хор нөлөөгүй, буруу гажуугүй санаа); **зөв тал** (а. хүний баруун гар тал; б. морь малын биений зүүн тал буюу морддог тал); **зөв хөл** (морь мал зэрэг амьтны зүүн хөл); **зөв гар** (а. хүний баруун гар; б. баруун гарын чиглэл); **зөв үүд** (гэрийн үүдний зүүн этгээд); **зөв эргэх** (а. нарны зүгийг дагаж тойрох; б. баруун гарыг дагаж эргэх); **зөв энгэр** (дээл хувцасны энгэр баруун тийш хандсан нь); **нар зөв** (нар эргэх чигийг дагах нь); **зөв бичих дүрэм** (ямар нэг хэлний бүх үгийг хэрхэн бичих тухай журамлан тогтоосон зүй); **зөв дуудах ёс** (ямар нэг хэлний бүх үгийг **яаж** дуудах тухай журамлан тогтоосон зүй.

ЗӨВДӨХ I 1. хүний үйл явдал зүйтэй нийлэмжтэй болох; 2. буруугаар явснаа оорч зөвт орох.

ЗӨВДӨХ II зөвших, зөвлөлдөх; *зөвдөн хэлэлцэх, ярилцах.*

ЗӨВЛӨГЧ зөвлөх хүн, зөвлөлгөө өгдөг хүн.

ЗӨВЛӨЛ үйл ажлыг хамтран хэлэлцэх хурал зөвлөлгөөний газар буюу байгууллага; *Сайд нарын зөвлөл; хотын зөвлөл; үйлдвэрчний эвлэлийн төв зөвлөл.*

ЗӨВЛӨЛГӨӨН зөвлөх үйлийн нэр; *сайн малчдын зөвлөлгөөн; эхчүүдэд зөвлөлгөөн өгөх; зөвлөлгөөнд суух.*

ЗӨВЛӨЛДӨХ аливаа тогтоох төлөвлөх үйл хэргийг олноороо хамтран хуралдаж хянан шүүмжилж хэлэлцэх; *зөвлөлдөн хэлэлцэх.*

ЗӨВЛӨЛТ зөвлөл бүхий; *зөвлөлт засаг; зөвлөлт байгуулал; Зөвлөлт Холбоот Улс; Зөвлөлтийн аж үйлдвэр; Зөвлөлтийн шинжлэх ухаан.*

ЗӨВЛӨХ I 1. бусдаас санаа эрэн асууж хэлэлцэх; *хэрэг зөвлөх; зөвлөн хэлэлцэх; би тантай зөвлөх саналтай; зөвлөх эрх олох;* 2. зөвлөгч; *элчин сайдын зөвлөх; зөвлөх түшмэл.*

ЗӨВЛӨХ II 1. хүний оюун, хүчин хүрэлцэн чадах, дөнгөх; *би тэр ажлыг хийж зөвлөх байх гэж үзнэ;* 2. эд юмны эн хэмжээ зөвхөн хүрэлцэх; *энэ хэсэг даавуу хүүхдийн дээлд зөвлөнө бий.*

ЗӨВЛӨХ III дээл хувцасны дотрыг гадар өнгөнд тохируулж тааруулах; *дээлийн дотор зөвлөх.*

ЗӨВЛҮҮЛЭХ зөвлөхийн үйлдүүлэх хэв.

ЗӨВТГӨХ зөвтөхийн үйлдүүлэх хэв, зөв болгох.

ЗӨВТӨХ зөв болох; *миний ажил ёстой зөвтсөн.*

ЗӨВХӨН 1. аливаа юмны явцав хүрэлцсэн тохирсон буюу хүрэлцүүлж тохируулах; *савандаа зөвхөн багтав; зөвхөн хоёр хоногийн хоолтой явав;* 2. бусад зүйлүүдээс нэгийг онцлон үзэх; *үгсийн аймгийн дотроос зөвхөн үйл үгийг судлана.*

ЗӨВШИЛДӨХ олноороо зөвших, зөвлөлдөх.

ЗӨВШИХ аливаа хэрэг явдлыг санал солилцон, шүүмжлэн хэлэлцэх; *бүгдээрээ зөвшөөл бурууг үй, бүлээн усаар угаавал хирүй з үй р.*

ЗӨВШЛӨГ зөвшин хэлэлцэх үйлийн нэр.

ЗӨВШӨӨМӨР 1. аливаа хэргийг өөрчлөхгүй нэгэн санаагаар дагаж гүйцэтгэх; 2. аливаад зөвшөөрөмтгий; *зөвшөөмөр хүн.*

ЗӨВШӨӨРӨГДӨХ зөвшөөрөхийн үйлдэгдэх хэв.

ЗӨВШӨӨРӨЛ зөвшөөрөх үйлийн нэр; *зөвшөөрөлтэй хэрэг; зөвшөөрөл авсан; зөвшөөрөл олгох; нийтээрээ зөвшөөрөн хүлээсэн хэрэг.*

ЗӨВШӨӨРӨЛЦӨХ зөвшөөрөхийн үйлдэлцэх хэв.

ЗӨВШӨӨРӨХ зөвт үзэх, дагаж нийлэх, ойшоон дагалдах; *над чөлөө олгохыг зөвшөөрнө үү; танд зөвшөөрнө; үл зөвшөөрөх.*

ЗӨВШӨӨРҮҮЛЭХ зөвшөөрөхийн үйлдүүлэх хэв.

ЗӨВШӨӨХ зөвшөөрөх, санал зорилго нийлэлцэх, дагах; *дуртайяа зөвшөөх биз ээ; түүнийг зөвшөөх хэрэгтэй байсан.*

ЗӨГИЙ а м ь т а н цэцгийн шүүсээр бал боловсруулдаг нисдэг шавьж; *зөгий тэжээх; зөгий тэжээх газар;* **зөгийн бал** (зөгий, цэцгийн шүүсийг үүртээ цуглуулж боловсруулсан амтлаг зүйл); **зөгийн үүр** (зөгийн орогнон үүрлэх байр).

ЗӨГНӨГДӨХ 1. ирээдүйд тохиолдох ямар нэгэн үйл явдал урьдаас сэрэгдэх; 2. өдөр явсан хэрэг явдал, шөнө зүүдэнд орж сэрэгдэх.

ЗӨГНӨЛ зөгнөх үйлийн нэр.

ЗӨГНӨЛТ зөгнөл бүхий; *зөгнөлт үран зохиол.*

ЗӨГНӨХ юмыг урьдаас төсөөлөн мэдэх; *бороо орохыг зөгнөх; хөдөө явахыг зөгнөх.*

ЗӨГНҮҮЛЭХ зөгнөхийн үйлдүүлэх хэв.

ЗӨГӨН: зөгөн халуун чийгтэй болоод халуухан.

ЗӨН I хүний санаанд урьдаас сэрэгдэн төсөөлөгдөх, авьяас; **зөн билэг** (сэрэгдэн төсөөлөх оюун мэдэл); **зөн мэдэл** (юмыг зөгнөн мэдэх мэдэл).

ЗӨН II тоосго, шатаасан туйпуу.

ЗӨНГӨӨР зоргоор нь, аяар нь; *зөнгөөр нь тавих; зөнгөөр нь орхих.*

ЗӨНГӨХ гэрийн юмыг өөр газарт сэмээр нуун хүргэх.

ЗӨНД: зөнд нь 1. дураар нь, зоргоор нь; *зөнд нь тавих; зөнд нь байлгах;* 2. их л; *айраг зөнд нь уув; зөнд нь газар ухуулав.*

ЗӨНДӨӨ 1. гэм халгүй, мөрөөрөө; *зөндөө хүн; зөндөө явна;* 2. хааяагүй элбэг дэлбэг; *зөндөө мал; зөндөө мод;* 3. их; *хоол унд зөндөө үлдэв; би зөндөө явав; зөндөө удав.*

ЗӨНӨГ хүн амьтан их насалж ухаан мэдрэл нь балай болсон нь; *манай энэ өвгөн зөнөг болсон юм.*

ЗӨНӨГЛӨХ хүн амьтны зөнөг болох; *та битгий зөнөглөөд бай.*

ЗӨНӨГЛҮҮЛЭХ зөнөглөхийн үйлдүүлэх хэв.

ЗӨНӨГШИХ 1. хүн амьтны нас хөгширч ухаан мэдрэл балай болж зөнөх шинж орох; 2. архи дарс хэтэрхий ууж согтох.

ЗӨНӨХ хүн амьтны нас хөгширч ухаан мэдрэл балай болох, зөнөглөх; *энэ нохой зөнөж байгаа юм.*

ЗӨНТӨХ хүн насжиж санаа сэтгэл дордож, хэвийн байдлаас доройтох.

ЗӨНЧ юмыг урьдаас сэрэн мэдэгч; *зөнч хүн; зөнч нохой.*

ЗӨӨВӨР зөөсөн юм; *зөөвөр зөөх; зөөвөр хүргэх.*

ЗӨӨВӨРЛӨХ зөөвөр хийх; *эндээс тэнд зөөвөрлөх хэрэгтэй.*

ЗӨӨВӨРЛҮҮЛЭХ зөөвөрлөхийн үйлдүүлэх хэв.

ЗӨӨГ 1. хоол ундны бүлээвтэрхэн нь; *зөөг цай залгилав; хоол зөөг болжээ;* 2. зарим юмны зөөлөвтөрхөн хөдөлгөөн нь; *зөөг салхи; бороо зөөг орж байна;* 3. аяархан, зөөлөн; *ширүүн явж болохгүй, зөөг явах хэрэгтэй.*

ЗӨӨГДӨХ I 1. зөөг болох; *цай зөөгдөх;* 2. *хэтэрхий зөөг болох.*

ЗӨӨГДӨХ II зөөхийн үйлдэгдэх хэв.

ЗӨӨГДҮҮ зөөг байдалтай, зөөг шинжтэй.

ЗӨӨГДҮҮЛЭХ зөөгдөхийн үйлдүүлэх хэв, зөөг болгох.

ЗӨӨГДҮҮХЭН арай зөөгдүү, баахан зөөгдүү.

ЗӨӨГӨӨР зөнгөөр нь, аяар нь, дураар нь; *зөнгөөр нь явуулах хэрэгтэй.*

ЗӨӨГХӨН баахан зөөг, арай зөөг.

ЗӨӨГЧ I юм зөөдөг хүн; *цай зөөгч; ном зөөгч; шуудан зөөгч; хоол зөөгч; ачаа зөөгч.*

ЗӨӨГЧ II юм зөөдөг хэрэгсэл; *зөөгч пуужин.*

ЗӨӨГШИХ юмны зөөг болох; *цай зөөгшиж байна, уухгүй юү?*

ЗӨӨГШРӨХ зөөг болох төлөв орох.

ЗӨӨГШРҮҮЛЭХ зөөгшрөхийн үйлдүүлэх хэв.

ЗӨӨГШҮҮЛЭХ зөөгшихийн үйлдүүлэх хэв, зөөг болгох.

ЗӨӨЛГӨХ зөөхийн үйлдүүлэх хэв.

ЗӨӨЛГҮҮЛЭХ зөөлгөхийн үйлдүүлэх хэв.

ЗӨӨЛДӨХ хэтэрхий зөөлөн болох.

ЗӨӨЛДҮҮЛЭХ зөөлдөхийн үйлдүүлэх хэв.

ЗӨӨЛӨН хатуу ширүүн, хатан гэдгийн эсрэг утга; 1. даралтын нөлөөнд хялбархан автдаг, хэлбэр дүрсээ алдамтгай чанартай юм; *зөөлөн төмөр; зөөлөн мод; зөөлөн чулуу;* 2. илбэргүү унган байдалтай юм; *зөөлөн үс; зөөлөн эдлэл; зөөлөн хоол;* 3. эелдэг номхон зан байдалтай; *зөөлөн хүн; зөөлөн зан; зөөлөн харц;* 4. хөнгөн хялбар, амархан; *зөөлөн ажил; зөөлөн оёдол;* 5. ялгум аятай, аяархан; *зөөлөн явдалтай морь; зөөлөн явах; зөөлөн вагон;* **зөөлөн сэтгэл** (уярангуй сэтгэл; *их зөөлөн сэтгэлтэй хүн байж билээ);* **зөөлөн гийгүүлэгч** (өгүүлэхэд хэлний дунд этгээд тагнайд ойртдог гийгүүлэгч); **зөөлөн суудал** (а. суухад хатуу биш, аятай суудал; б. галт тэргээр зорчигчдод хөлслөх тохилог тасалгаа); ☆ **зөөлний тэмдэг** (цагаан толгойн 'Ь, үсэг).

ЗӨӨЛРӨХ хатуу ширүүн юмны зөөлөн болох; *салхи зөөлөрч байна;* **зөөлөрсөн гийгүүлэгч** (нэгэнт зөөлөн болсон гийгүүлэгч).

ЗӨӨЛРҮҮЛЭХ зөөлрөхийн үйлдүүлэх хэв.

ЗӨӨЛТГӨХ зөөлөн болгох.

ЗӨӨЛТӨХ улмаар зөөлөн болох.

ЗӨӨЛХӨН баахан зөөлөн, арай зөөлөн.

ЗӨӨЛШИХ зөөлөн шинж орох, зөөлөн шинжтэй болох.

ЗӨӨЛШҮҮЛЭХ зөөлшихийн үйлдүүлэх хэв.

ЗӨӨМӨР аливаа ачаа тээш зэргийг биеэр үүрэн зөөх хүн; *зөөмөр хүн;* **зөөмөр болох** (юмыг зөөсөн байдал үзүүлэх).

ЗӨӨМТГИЙ зөөдөг зантай.

ЗӨӨМХИЙ зөөмтгий.

ЗӨӨН: зөөн дулаан чийгтэй бөгөөд дулаан; **зөөн халуун** (баахан халуувтар).

ЗӨӨНГӨ зөөг.

ЗӨӨНГӨДҮҮ арай зөөг, баахан зөөг.

ЗӨӨНГӨДҮҮХЭН арай зөөнгөдүү, баахан зөөнгөдүү.

ЗӨӨР хурааж хуримтлуулсан хөрөнгө хогшил; *хөрөнгө зөөр* х о р ш..

ЗӨӨРЖИХ зөөр хөрөнгө ихтэй болох.

ЗӨӨСГӨРӨХ халуун юмны баахан хөрөх, зөөг болох;*цай зөөсгөрөх.*

ЗӨӨСГӨРҮҮЛЭХ зөөсгөрөхийн үйлдүүлэх хэв.

ЗӨӨТГӨРӨХ 1. хүнд өвчин бага зэрэг ялаар болох; 2. хүний хилэн гаслан баахан намхрах; 3. халуун хоол цай зэргийн зөөсгөрөх.

ЗӨӨХ юмыг нэг газраас нөгөө газарт шилжүүлэн хүргэх; *ачаа зөөх; хүн зөөх; гэр зөөх; зөөж буух;* **хов зөөх** (хов хэлэх).

ЗӨӨХИЙ 1. сүүний өрөм; **өрөм зөөхий** х о р ш.; **зөөхий тавих** (буцламгай сүүг самчин хөөсрүүлж, хөөстэй сүүг бага бага саванд хийж өрөм тогтоох); 2. өрмийг хайлж гурил эзэгий мэтийг хольсон нэгэн зүйл идээ; *зөөхий хайлах.*

ЗӨРЛӨГ зөрсөн юм, зөрсөн газар; *туурганы зөрлөг; замын зөрлөг; зөрлөг зам дээр уулзъя; төмөр замын зөрлөг.*

ЗӨРӨГ 1. юмны зөрсөн газар, зөрлөг, зөрөө; 2. тодорхой биш нарийн жим зам; *зөрөг зам.*

ЗӨРӨЛ зөрчил, тэмцэл, зөрөлдөөн, тэмцэлдээн.

ЗӨРӨЛДӨӨН санал нийлэлцэхгүй зөрөлдсөн нь; **зөрөлдөөн тэмцэлдээн** х о р ш..

ЗӨРӨЛДӨХ 1. зөрөхийн үйлдэлдэх хэв, зөрчих, тэмцэлдэх; 2. бай-бай-буюу олноороо зөрөх.

ЗӨРӨЛДҮҮЛЭХ зөрөлдөхийн үйлдүүлэх хэв.

ЗӨРӨЛЦӨХ 1. зөрөхийн үйлдэлцэх хэв, зөрөлдөх, тэмцэх; 2. зөрөлдөх, хэрэлдэх.

ЗӨРӨМГИЙ зөрдөг зантай, зөрөх зантай.

ЗӨРӨМТГИЙ зөрүүд, зөрөмгий.

ЗӨРӨӨ зөрөх үйлийн нэр, зөрүү, зөрлөг; *зөрөө ихтэй; зөрөө багатай; их багын зөрөө.*

ЗӨРӨХ 1. ёс журам, хэв байдлыг үл дагах, зөрчих; *дүрэм зөрөх; санаатайгаар зөрөх;* 2. юмны хоёр тийш өнгөрөн явах; *замаар машин зөрөх;* 3. хоёр юмны солбих; *савх зөрөх;* 4. тохирч таарахгүй болох; *тоо зөрөх; санаа бодлого зөрөх.*

ЗӨРҮҮ 1. аливаа юмны хөндлөн гулд бишташуу; *зөрүү зам; зөрүү ширхэг;* 2. хүн амьтны зан явдал нийцэхгүй гажуу; *зөрүү зантай хүн; зөрүү буруу хэрэг;* 3. зөрөө, зөрсөн нь; *цалингийн зөрүүг олгох; зөрүүгий нь гаргах; бидний санал зөрүү байна;* **зөрүү хараат** (нэг зүйл дуран авай).

ЗӨРҮҮД этгээд гажуу буюу зөрөмгий зан байдалтай; *зөрүүд хүн.*

ЗӨРҮҮДЛЭХ зөрүүд зан гаргах.

ЗӨРҮҮЛДҮҮЛЭХ зөрүүлдэхийн үйлдүүлэх хэв.

ЗӨРҮҮЛДЭХ юмыг зөрүү болгох; *ширдэг дэвсгэрийг зөрүүлдэн өдөсэх; юм хумыг зөрүүлдэн хураах; удирга зөрүүлдэн залгах.*

ЗӨРҮҮЛЭХ зөрөхийн үйлдүүлэх хэв, зөрөхөд хүргүүлэх.

ЗӨРЧИГЧ зөрчсөн этгээд; *хууль дүрэм зөрчигч; сахилга журам зөрчигч.*

ЗӨРЧИД манж угсаатан; *зөрчид аймаг; зөрчид хүн*

ЗӨРЧИЛ нөгөөтэйгөө харшиж тохиролцохгүй зөрөх үйлийн нэр; **зөрчил тэмцэл** х о р ш.; *тэр хоёр хоорондоо их зөрчилтэй байна.*

ЗӨРЧИЛДӨӨН зөрөлдөөн, тэмцэлдээн, маргалдаан.

ЗӨРЧИЛДӨХ зөрчихийн үйлдэлдэх хэв, харилцан тэмцэлдэн зөрөлдөх; *зөрчилдөх тэмцэлдэх.*

ЗӨРЧИЛДҮҮЛЭХ зөрчилдөхийн үйлдүүлэх хэв.

ЗӨРЧИЛТ зөрчил бүхий, зөрчилтэй

ЗӨРЧИМТГИЙ ямагт зөрчих зантай.

ЗӨРЧИХ ёс зүй ба үг заавар зэргийг дагахгүй зөрөх, маргаж тэмцэх; *хууль дүрэм зөр-*

чих; сахилга жүрам зөрчих; хэв заншил зөрчих; ёс зөрчих; журам зөрчих.

ЗӨРЧҮҮЛЭХ зөрчихийн үйлдүүлэх хэв.

ЗӨЧИХ бусдын үг санааг дагахгүй зөрүүд зан гаргах.

ЗӨЧҮҮД зөрүүд зантай; *зөчүүд хүн; зөчүүд мал.*

ЗӨЧҮҮДЛЭХ зөчүүд зан байдал гаргах.

ЗУВАГ ус урсгах битүү нүх суваг.

ЗУВАХ амьтны харайж зугадахгүй мөлхөж өвсөн доогуур шургалан буруулах.

ЗУВГА уулын хажуу газрын бэрх жим зам; *зувга зам; зувга жим; зувга дагаж явах.*

ЗУВЦАА уг нь үстэй дээлийн нэр, одоо элдэв үстээр доторлож, гадар өнгө татаж хийсэн дээл, зарим газар нэхий буюу үзүүрсгээр доторлосныг зувцаа гэдэг.

ЗУВЦААЛАХ 1. дээлийн гадуур, дан дээл мэтийн юмыг давхцан өмсөх; 2. үстэй дээлд гадар татах; 3. зувцаа дээл өмсөх.

ЗУВЧИХ 1. хүний гүжирмэгээр аашлах; *амь зувчин явах* 2. хүн амьтны юмнаас зайлсхийн булталсхийн буруулж явах; *ятуу зувчих;* 3. дамдамжиж алга болох; *миний ном зувчиж үгүй болов.*

ЗУВЧУУЛАХ дамжуулах, зайлуулах зэргээр юм хумыг үгүй болгох; *малаа зувчуулах; ном зувчуулах.*

ЗУГАА саная сэтгэлийг сонирхуулах буюу уйтгарыг сэргээх үйлийн нэр; *зугаа хийх; зугаа болгох;* **зугаа цэнгэл** х о р ш.; *хоол болтол шийр зугаа* з ү й р; *зугаагаа гаргах.*

ЗУГААЛАХ зугаа хийж явах, зугаацах; *бид ууланд зугаалахаар явцгаав.*

ЗУГААЛГА зугаалах үйлийн нэр; *сайн өдрийн зугаалга.*

ЗУГААЛМААР зугаалж болмоор.

ЗУГААЛУУЛАХ зугаалахын үйлдүүлэх хэв.

ЗУГААТАЙ зугаа бүхий, уйтгаргүй, баяр цэнгэлтэй, хөгжөөнтэй; *зугаатай ажил; зугаатай тоглоом; зугаатай хүн.*

ЗУГААТАЙХАН баахан зугаатай, арай зугаатай.

ЗУГААХИЙХ зугаацах, зугаалах.

ЗУГААЦАХ 1. уйтгарыг сэргээх буюу бухиндлыг тайлах; 2. юмыг сонирхон үзэх хийх зэргээр зорчин явах.

ЗУГААЦУУЛАХ зугаацахын үйлдүүлэх хэв.

ЗУГАДАХ зугтах.

ЗУГАДУУЛАХ зугатуулах.

ЗУГИЙ у р г а м а л хоёр наст ургамал, нэгдүгээр жилд үндэс орчмын навч шүүслэг, хоёрдугаар жилд иш ургана, цэцэг улаавтар говь талын бүс, чулуурхаг, мөн элсэрхэг хөрстэй газар ургана, зарим нутагт хөхөөний айраг ч гэнэ.

ЗУГАТААЛГАХ зугтаахын үйлдүүлэх хэв, зугтахад хүргүүлэх.

ЗУГТААХ зугадах, зугадаж зайлах.

ЗУГТАХ юмнаас буруулан зайлж одох; *зугтан гарах; зугтан ирэх; зугтахыг завдах.*

ЗУГТЛАГА зугтах үйлийн нэр.

ЗУГТУУЛАХ зугтахын үйлдүүлэх хэв.

ЗУГУУ юмыг асар түргэн буюу чанга бишгээжим алгуур хийх, үйлдэх; **югуу зугуу** х о р ш.; *зугуу татсан нь дээр; зугуу явж сурах хэрэгтэй; зугуу иди зугуу бичиж сур!*

ЗУГУУХАН нилээд зугуу, арай зугуу.

ЗУД гол төлөв байгалийн эрхшээл нөлөөнөөс болж, хүн малын идэш ууш нэн ховордож нийтээр маш их гачигдал үзэх цаг үе; **зуд гачиг; зуд турхан** х о р ш.; **ган зуд** (зуны цаг хур бороогүйгээс болж газар хэтэрхий гандаж гачигдах цаг үе); **хар зуд** (өвөл цас орохгүй, хараар хүйтэрч гачигдах цаг); **цагаан зуд** (өвөл маш их цас орж гачигдах цаг); **өлөн зуд** (идэш уушийн зүйл маш ховор цаг); **зуд болох** (ган гачиг тохиох буюу цас шуурга хэтийдэж хүн мал зудэх сүйдэхэд хүргүүлэх нөхцөл учрах); **зудтай тэмцэх** (зудад нэрвэгдсэн хүн малд туслах); *зуд болоход нохой таргалдаг, зовлон болоход лам таргалдаг* з ү й р.

ЗУДАРХАГ зудтай буюу зудын шинж байдалтай.

ЗУДАРХУУ зудын шинж байдалтай.

ЗУДЛАХ I зуд гачиг тохиолдох, зуд болох.

ЗУДЛАХ II задлах, зудрахын үйлдүүлэх хэв, зудрахад хүргүүлэх.

ЗУДЛУУЛАХ зудлахын үйлдүүлэх хэв.

ЗУДРАХ юмны боодол баглаа буюу эрч сүлжээс, наалт, оёдол мэтийн задрах, салах, тархах; *боодол зудрах: баглаа зудрах; наалт зудрах; оёдол зудрах; хадаасараа зудрах; үг зудрах.*

ЗУДТАЙ зуд бүхий, зуд ихтэй.

ЗУДТАХ зудтай болох, зудын шинж орох.

ЗУДЧИХ 1. юмыг байн байн буюу зэрэг зэргээр зудлах; *хайрцаг зудчих;* 2. юмны боодол баглаа буюу хувцас хунар мэтийн оёдол өөрөө алдарч ханзрах, зудрах.

ЗУДЧУУЛАХ зудчихын үйлдүүлэх хэв.

ЗУДШИХ зудын шинж байдалтай болох.

ЗУЗААДАХ хэтэрхий зузаан болох.

ЗУЗААДУУЛАХ зузаадахын үйлдүүлэх хэв.

ЗУЗААЛАГ юмны нилээд зузаан нь; *зузаалаг биетэй хүн; зузаалаг эд.*

ЗУЗААЛАХ зузаатгах, зузаан болгох, арвин их болгох; *дэвсгэр зузаалах; жийргий нь зузаалах; хөрөнгөө зузаалах.*

ЗУЗААЛУУЛАХ зузаалахын үйлдүүлэх хэв.

ЗУЗААН I нимгэн гэдгийн эсрэг утга, юмны нимгэнгүй гүн хол буюу арвин их; *өргөн зузаан уул; гүн зузаан ус; зузаан банз; зузаан дэвсгэр; хөрөнгө зузаан айл; хоёр метрийн зузаан мөс;* **зузаан цай** (цайны навчийг зассварлан болгож хэвт шахан хийсэн хэвлэмэл цай); **зузаан ховол ургамал** (өндөр нь хэд хэдэн хос алд, нүцгэн ховлын навчтай адил навчтай, өвөл зулгарахгүй, цагаавтархан дурстай, зулам шар нэгэн зүйл мод).

ЗУЗААН II маш дотно; *зузаан ханилсан нөхөр; бат зузаан найрамдалтай; зузаан холбоо тогтоох.*

ЗУЗААНДУУ арай зузаан, нилээд зузаан.

ЗУЗААРАХ зузаан болох; *үүл зузаарах.*

ЗУЗААРУУЛАХ зузаарахын үйлдүүлэх хэв, зузаан болгох.

ЗУЗААСАХ улам зузаан болох.

ЗУЗААСГАХ зузаасахын үйлдүүлэх хэв.

ЗУЗААСГУУЛАХ зузаасгахын үйлдүүлэх хэв.

ЗУЗААТАХ улмаар зузаан болох.

ЗУЗААТГАХ улам зузаан болгох; *дэвсгэр зузаатгах; найрамдал зузаатгах.*

ЗУЗААТГУУЛАХ зузаатгахын үйлдүүлэх хэв, зузаатгахад хүргүүлэх.

ЗУЗААХАН нилээд зузаан, баахан зузаан.

ЗУЗАЙЛГАХ зузайхын үйлдүүлэх хэв, зузгар болгох.

ЗУЗАЙХ зузгар болох.

ЗУЗГАР амьтны хацар шанаа хэвийн жишээнээс товгор, цулцгар; *зузгар хацартай хүүхэд.*

ЗУЙГАР зусар бялдууч; *зуйгар хүн зулгаа барна, зуудаг нохой соёогоо барна* з ү й р.

ЗУЙГАРЛАХ зусарлах, бялдуучлах.

ЗУЙРААЧ зуйрах заншилтай хүн.

ЗУЙРАХ 1. зусардах, бялдуучлах, долдойлох; 2. хов зөөж үймүүлэх; 3. саймсарч хутгах.

ЗУЙРГАН 1. зусарч зуйгар зантай; 2. ховч залхай.

ЗУЛ хөвөнгийн голыг тосонд тавьж шатаан хэрэглэх гэрэл; *цөгцтэй зул; лаа зул; тосон зул; зулын цөгц;* **зул шандах** (зулын гол хэтэрхий нарийдаж гэрэл нь дутмагдах); **зул мандах** (зул ноцох ба зулын гэрэл улам их болох); **зул бүхэх, зул жаргах** (зул унтрах); **зул барих** (зул шатаах, зул асаах); ☆ **зул сар** бэлгийн улирлын өвлийн эхэн сар).

ЗУЛАВЧ тэрэгний тэнхлэгийг хавчихаар аралд хадсан муруй төмөр.

ЗУЛАГ гутлын ул түрий хоёрын хоорондох хэсэг хувь; *гутлын зулаг; зулаг дээрээ угалзтай гутал ;зусарч хүн зулгаа барна; хүрэн зулагтай гутал өмссөн хүн.*

ЗУЛАЙ хүний толгойн орой магнай хоёрын хоорондох хэсэг газар; *хүүхдийн зулай.*

ЗУЛАМ 1. өндөгний хатуу хальсны дотуурхи нимгэн хальс; *өндөгний зулам;* 2. модны дурсны дотуурхи нимгэн хальс; *модны зулам;* 3. самар хонгорцгийн идээний гаднах нимгэн **хальс; *самрын зулам.***

ЗУЛАМЛАХ зулмыг арилгах, цэвэрлэх.

ЗУЛАМЛУУЛАХ зуламлахын үйлдүүлэх хэв.

ЗУЛАГДАХ зулахын үйлдэгдэх хэв.

ЗУЛАХ юманд ямар нэгэн юмыг зайгүй тэгш эгнүүлэн эвлүүлэн тохируулах, тавих; *зүлэг зулж суулгах; дэвсгэр зулж дэвсэх; дээлд хөвөн зулах; ноос зулах; хурганд өвс зулж дэвсэх* зулах машин (зулдаг машин).

ЗУЛУУЛАХ зулахын үйлдүүлэх хэв, зулагдах.

ЗУЛБАГАНАХ зулбагар юмны үргэлжлэн хөдлөх.

ЗУЛБАГАР зулбан, нимгэн, нявталхан үстэй; *зулбагар арьс.*

ЗУЛБАДАГ 1. зулбадай, зулбадас; 2. зулбасга.

ЗУЛБАДАЙ 1. булга шилүүсний зэрэг нарийн үст амьтны үс нь гүйцээгүй маш тачир нимгэн арьс; 2. зулбасга.

ЗУЛБАДАС 1. зарим амьтны зулбарч унасан арьс хальс; *могойн зулбадас.*

ЗУЛБАДАС II дутуу төрсөн хурга ишигний арьс.

ЗУЛБАДАСЛАХ дутуу төрөх, зулбадас гаргах.

ЗУЛБАЙХ зулбагар болох.

ЗУЛБАЛЗАХ зулбагар юмны байн байн хөдлөх.

ЗУЛБАН амьтны үс ноос хэвийн жишээнээс дэндүү тачир богино; *зулбан мал; зулбан нохой; зулбан тачир арьс үс;* **зулбан тайга** (нэг зүйлийн нохой).

ЗУЛБАРАЙ 1. зулбадаг, зулбадас, зулбадай; 2. зулбасга.

ЗУЛБАРАН зулбадаг арьсаар хийсэн зувцаа дээл.

ЗУЛБАСГА хонь ямааны хоног сар гүйцээгүй дутуу төрсөн төлийн арьс; *ишигний зулбасга.*

ЗУЛБАХ I 1. боосдосон амьтны хоног сар гүйцээгүй дутуу төрөх; 2. зуны цаг могойноос арьс шувтран унах.

ЗУЛБАХ II юмнаас айн тэвдэж зайлах, зугадах; *арай чарай амь зулбаж гарав;* **зугадах зулбах** х о р ш.

ЗУЛГА хүч нэмэгдүүлэх үг; *зулга цохих; зулга угаах; зулга татах; зулга маажих.*

ЗУЛГААГДАХ 1. зулгаахын үйлдэгдэх хэв; 2. зулгаалгах.

ЗУЛГААЛГАХ 1. зулгаахын үйлдүүлэх хэв; 2 .зулгаагдах.

ЗУЛГААХ 1. үс өвс зэрэг юмыг гараар үхтээн авах; *үс зулгаах; өвс зулгаах;* 2. амьтны идэшний зүйлийг ам шүдээр зууж үхтээх; *чоно зулгаачихсан мал; нохой зулгаав; шүдээрээ зулгаах;* 3. ш и л ж с э н нялх амьтны үргэлжлэн хөхөх; *энэ хүүхэд чинь өхөө зулгааж л байна.*

ЗУЛГАЛАХ юмны арьс үс, хальс будаг зэргийг хуулж авах, унагах.

ЗУЛГАЛУУЛАХ зулгалахын үйлдүүлэх хэв, зулгарахад хүргүүлэх.

ЗУЛГАРАХ юмны арьс үс, хальс будаг зэргийн өөрөө унах, халцрах; *өвс модны цэцэг навч зулгарах; арьсны үс зулгарах; нэхийний үс нь зулгарчихжээ.*

ЗУЛГАРУУЛАХ зулгарахын үйлдүүлэх хэв, зулгарахад хүргүүлэх.

ЗУЛГАРХАЙ зулгарсан газар; *толгойны зулгархай; зулгархай үстэй арьс.*

ЗУЛГУЙ зусар хуурмаг сайхан ааш бааш; **зусар зулгуй** х о р ш.

ЗУЛГУЙДАХ зулгуй зан ааш гаргах.

ЗУЛГУЙДУУЛАХ зулгуйдахын үйлдүүлэх хэв, зулгуйдахад хүргүүлэх.

ЗУЛГУЙЧ зусар хуурмаг ааш зан гаргахдаа чадамгай; *зулгуйч хүн зулаггүй, зусаг ямаа шимгүй* з ү й р.

ЗУЛДАРГАНА у р г а м а л хужрын хувь багатай зөөлөн хөрстэй газар ургадаг, өнгө хэлбэр цагаан шавагтай адил нэгэн зүйл ургамал.

ЗУЛДАХ юмнаас бурууллан дутаах, зугадах; **зугадах зулдах** х о р ш.; *амь зулдах.*

ЗУЛЗАГА 1. зарим амьтны сая төрсөн төл; *араатны зулзага; жигүүртний зулзага; ангирын зулзага;* 2. сая ургасан жижигхэн мод бут; *зулзаган хайлаас; зулзаган шаваг; зулзаган харгана.*

ЗУЛЗАГАЛАХ 1. амьтны үр зулзагаа гаргах; *шувуу зулзагалах;* 2. мод бутны гөлөг цухуйх; *мод зулзагалах.*

ЗУЛЗАГАЛУУЛАХ зулзагалахын үйлдүүлэх хэв.

ЗУЛМААХ зулмахын үйлдүүлэх хэв, **зулмахад** хүргүүлэх.

ЗУЛМАЛАХ 1. юмны зулмыг **арилгах**; 2. юмны үсийг зумлах.

ЗУЛМАЛУУЛАХ зулмалахын үйлдүүлэх хэв, зумлуулах.

ЗУЛМАХ юмны үс хальс зумран унах, гуужих.

ЗУЛМУУЛАХ зулмахын үйлдүүлэх хэв.

ЗУЛРАХ 1. зайлах, зугадах; *хүрэн морь зулран зугадав*; 2. гулрах, явдлаа алдах, **завхрах**; *нэгмөсөн зуларсан амьтан болжээ*.

ЗУЛРУУЛАХ зулрахын үйлдүүлэх хэв.

ЗУЛУУЛАХ зулахын үйлдүүлэх хэв.

ЗУЛХАЙ зулахад бэлтгэн савж сэмлэсэн ноос хөвөн; **өнгө зулхай** (эсгий хийхэд зузаан нимгэн хоёр давхар зулсны нимгэн зулхай; цагаан зулхай ч гэдэг); **дотор зулхай** (эсгий хийхэд зузаан нимгэн хоёр давхар зулсны зузаан зулхай, хар зулхай ч гэдэг).

ЗУЛЧ I амьтны харвисны дотоод дахь цус бөөм, ус сэлт, *зээрний зулч*.

ЗУЛЧ II ш а ш и н сүм дуганд зул барих үүрэгтэй хүн.

ЗУМ алсан үхэр, хонь гахай зэргийн үс өрвөлгийг буцламгай усанд хэврэгшүүлэн зулгаах, хусах зэргээр арилгаж хурим дайлга мэтэд бүхэл хэвээр хэрэглэх; *зум хийх; зум идэх; ямааны зум; хонины зум*.

ЗУМЛАХ алсан мал тэжээврийн амьтны үс өрвөлгийг буцламгай усанд шалзлан зулгаах, хусах зэргээр арилгах ба арьсны үс өрвөлгийг зулгаан авах; **зулгаах зумлах х о р ш.**: *хонь зумлах; ямаа зумлах*.

ЗУМЛУУЛАХ 1. зумлахын үйлдүүлэх хэв; 2. зумлагдах.

ЗУМРАХ амьтны үс өрвөлөг зумран унах, гуужих.

ЗУМРУУЛАХ зумрахын үйлдүүлэх хэв.

ЗУН жилийн **дөрвөн** улирлын нэг, бэлгийн улирлын дөрөв тав, зургадугаар сарууд буюу хавар намрын хоорондох дулаан улирал; *хаалуун зун; зун цаг; зунаараа; зуны сайхан цаг; зуны халуун; зуны нар; зундаа халуун*; **зуны амралт** (зуны улиралд амрах тогтмол амралт); **зуны туйл** (өдрийн урт туйлдаа хүрэх хугацаа аргын улирлын зургадугаар сарын хорин хоёр буюу хорин гуравны орчим).

ЗУНГАГ I. сая төрсөн нялх амьтны баас; *хурганы зунгаг; хүүхдийн зунгаг*; 2. хүн амьтны **үсний хөлс, тослог**; *үсний зунгаг; ноосны зунгаг*.

ЗУНГАГЛАХ сая төрсөн нялх амьтны зунгаг гаргах.

ЗУНГАГТАХ зунгагтай болох.

ЗУНГАГШИХ зунгагийн шинжтэй болох.

ЗУНЖИН зуны турш; *зунжин ажил хийв; зунжин цэнгэв*.

ЗУНЖИХ хүн амьтан буюу **айл өрхийн** зуны цагийг туулан өнгөрүүлэх; *хотод зунжих; хөдөө зунжих*.

ЗУНШИХ зуншлага дэлгэрэн зуны шинж байдал орох.

ЗУНШЛАГА зуны цагт өвс ногоо дэлгэрч, малын сүү шим элбэгших зэргээр зуны шинж байдалтай болсон нь; *зуншлага сайтай; зуншлага муутай*.

ЗУНШУУЛАХ зуншихын үйлдүүлэх хэв.

ЗУРАА 1. амьтны гуя дахь говил; *гуяны зураа; зураа дээр нь дарсан тамга*; 2. амьтны нурууны хоёр этгээдийн гүдгэр журам; *нурууны зураа; зураа мах*; 3. уул нуруунаас доош салбарласан нарийн урт гүдгэр газар; *уулын зураа*.

ЗУРААДАС шууд зурсан мөр ором.

ЗУРААДАСЛАХ юманд зураадас гаргах.

ЗУРААС бүдгээр бүдэх буюу юм хумаар шүргэж гаргасан мөр ором; *зураас гаргах; зураас татах; чаг зураас*.

ЗУРААЧ зурахад мэргэжилтэй хүн.

ЗУРАГ I хавтгай юманд аливаа юмны төрх байдлыг гарган хийсэн дүрс; *зураг зурах; зургийн дэвтэр; зургийн харандаа*; **хадны зураг** (эрт дээр цагийн хүний хад чулуунд хүн амьтан зэргийг сийлэн гаргасан зураг); **тосон будгийн зураг** (тосоор найруулсан будгаар зурсан зураг); **усан будгийн зураг** (усанд уусдаг будгаар өнгө ялгаж зурсан зураг); **шог**

зураг (үнэн дүрээс хэтрүүлэн, шүүмжилж, шоглож зурсан зураг; *шог зургийн* уралдаан зарлав); **гар зураг** (оньсон техник хэрэглэлгүйгээр, гарын ураар зурсан зураг); **зураасан зураг** (аливаа юмыг будгаар үл ялган, зураас гаргаж зурсан зураг; *зураасан зургийн* үзэсгэлэн); **хар зураг** (будаагүй, сүүдэрлээгүй зураг); 2. хавтгай юманд аливаа юмны төлөв буюу мөн юмыг таних тэмдгээр төлөөлүүлэн **хийсэн нь**; **шугам зураг** (ерөнхий боловсролын сургуульд үздэг нэг зүйл хичээл; шугам зураг бол сурагчдад техникийн зургийн анхны мэдэгдэхүүнийг сургаж, техникийн зургийг ухаарах, хялбар зургаар тухайн юмыг хийх дадлага олгоно); **сохор зураг** (таних тэмдэг, уул тал, гол мөрөн, хот балгад зэргийг зураагүй хоосон үлдээсэн хүрээ зураг); **сохор зураг нөхүүлэх** (сохор зурагт таних тэмдэг, гол мөрөн далай тэнгэс, уул тал, хот балгад зэргийг нөхөн зурах); **газрын зураг** (газрын гадаргын зураг; *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын газрын зураг*); **гэрэл зураг** (аливаа юмны дүрс хэлбэрийг гэрэл мэдрэг бүхий хальсанд буулгасан зураг; *гэрэл зургийн газар; гэрэл зургийн лаборатори; гэрэл зургийн аппарат;* **зураг угаах** (хальс болон цаасан дээр буулгасан зургийг угааж илрүүлэх); **зураг буулгах** (гэрэл зургаар авсан зургийг боловсруулан цаасан дээр гаргах); **зураг авах** (аливаа юмны дүрсийг гэрэл мэдрэг хальсанд буулгах); **зураг сайтай бичиг** (цэвэр үзэмжтэй бичсэн бичиг).

ЗУРАГ II төөрөг, хувь төөрөг, заяа.

ЗУРАГДАХ зурахын үйлдэгдэх хэв.

ЗУРАГЛАХ зурагтай болгох, зураг гаргах.

ЗУРАГТ зураг бүхий; *зурагт сэтгүүл; зурагт сонин;* **зурагт радио** (дүрсийг хүлээн авах дэлгэц бүхий радио; *зурагт радиогоор ярив*).

ЗУРАГЧ (ИН) зураг зурах бүүлгахад мэргэжилтэй хүн; *гар зурагч; уран зурагч; гэрэл зурагчин.*

ЗУРАЛТ шугам зураас гаргах татахад хэрэглэх нимгэн хорголж бал.

ЗУРАМ а м ь т а н мэрэгч амьтны төрлийн жижиг амьтан, нүх малтаж оршино, өвс ургамлын үр, навч идэж амьдрана; өвлийн цагт ичнэ, ургамлын зүйлд хор хүргэдгээс гадна хүн малын халдварт өвчнийг тараах нь ч бий; арьс ба тосыг ашиглана; *зурмын арьсаар хөхүүр хийж, зулзаган шарилжаар бүлүүр хийж...* (ардын аман зохиол).

ЗУРАР у р г а м а л туулайн чих мэт навчтай, цагаан цэцэгтэй, шар туурцагтай, зургаан хэлтэстэй, маш үнэртэй нэгэн зүйл цэцэг.

ЗУРАХ I 1. юмны дүрс байдал буюу үсэг тэмдэг, хээ угалз мэтийг дүрэмнэн зураг гаргах; *хүн зурах; буга зурах; угалз зурах; навч зурах;* 2. бичих, нэрээ тавих; *гарын үсэг зурах; нэрээ зурах.*

ЗУРАХ II хавирах; *шүдэнз зурах.*

ЗУРВАС нарийн уртхан юм; *зурвас цаас; зурвас газар; зурвас бичиг тэмдэглэл; зурвас зам; зурвас даавуу.*

ЗУРВАСЛАХ I юмыг зурвас зурвас болгох.

ЗУРВАСЛАХ II модны холтос хальсыг хальчин авах; *мод зурваслах.*

ЗУРВАСЛУУЛАХ зурваслахын үйлдүүлэх хэв.

ЗУРВАСХАН баахан зурвас, нарийн зурвас.

ЗУРГАА (Н) тооны нэр, тав дээр нэгийг нэмсэн нь; *зургаан зургаа гучин зургаа;* **зургаан махбод** ш а ш и н (дөрвөн махбодын дээр огторгуйн махбод, сэтгэлийн махбод хоёрыг нэмээд); **зургаан сав** (хүн амьтны цөс, ходоод, олгой, нарийн гэдэс, давсаг, самшуу энэ зургаа); **зургаан уулзар** (дээд доод ба дөрвөн зүгийг хамтатган ийнхүү нэрлэнэ); **зургаан амт** (хэлний эрхтний мэдрэхүйд сэрэгдэх зургаан зүйлийн амт; амтайхан, эсгэлэн, эхүүн, гашуун, халуун, шорвог эдгээр болно); **зургаан нийлэлт** (дорно, өмнө, өрнө, умар, дээр, дор эдгээр зургаан зүг); **зургаан богино хавьс** (хүн амьтны хавирганы цээжин талын хоёр эттээдийн гурваад хавирга); **зургаан вишай** (нүд, чих, хамар, хэл, бие таван эрхтэн ба сэтгэл эдгээр зургаад сэрэгдэн мэдрэх юм буюу өшгө, дуу, үнэр, амт, хүртэхүй, сэрэхүй зургаа болно).

ЗУРГААДАЙ I у р г а м а л нэгэн зүйл модны нэр; *зургаадай таяг; зургаадай эрх.*

ЗУРГААДАЙ II хүний илүү ургасан зургадугаар хуруу.

ЗУРГААТАЙ зургаан настай.

ЗУРГАГААД тооны нэр, тус тус зургаа, зургаа орчим.

ЗУРГААНТАА зургаан удаа.

ЗУРГАДУГААР дэс тооны зургаад тохиолдсон нь.

ЗУРГУУЛ зургаан тоотой юмны хамт; *зургуул ирэв; зургуул бэлхэн байна.*

ЗУРДАС шугам зураас.

ЗУРДАСЛАХ юманд шугам зураас гаргах.

ЗУРЛАА зурсан, зураас.

ЗУРЛАГА зурах үйлийн нэр; *зурлага сайтай; зурлага муутай.*

ЗУРЛАХ байн байн буюу дахин дахин зурах.

ЗУРМАГ график.

ЗУРМАЛ зурж хийсэн юм; *зурмал зураг; зурмал морь.*

ЗУРУУЛАХ зурахын үйлдүүлэх хэв;

ЗУРХАЙ I х у у ч и р с а н тооны ба одон орны ухааны ерөнхий нэр; *тэнгэрийн зурхай; газрын зурхай; шар зурхай; хар зурхай.*

ЗУРХАЙ II 1. харвуулын сурыг өрөн тавьж харвах хэмжээ зураг татсан газар буюу харвуулын шагааг тавьж харвах дэвсгэр мод; *сурын зурхай; шагааны зурхай;* 2. х у у ч и р с а н алба ногдуулсан ногдол хувиар; *зурхай гаргах; зурхай хуваах;* 3. зарим нэгэн дүрс ором гаргасан зураг; *маяг зурхай; дүрэм зурхай;* **зурхай татах** (харвах сурын ар өвөрт хэмжээ зураг гаргах).

ЗУРХАЙЧ зурхайн ухаанд мэрэгжсэн хүн.

ЗУРХАЙЧЛАХ зурхай зурах, зурхайч байх.

ЗУРШИЛ урьдаас уламжилж ирсэн хэвшил; *зуршилгүй хэрэг бишүү; тийм зуршилтай байсан юм;* **зуршил гарах** (хэв заншил тогтох).

ЗУРШИХ 1. журам болон заншиж хэвших; 2. зор нь сайжран үүсэх тогтох.

ЗУРШМАЛ нэгэнт зуршил заншил болсон, хэвшмэл.

ЗУРШУУЛАХ зуршихын үйлдүүлэх хэв.

ЗУСААЛ зун эдлэгдэж, дутуу таргалсан мал; *зусаал морь; зусаал ат.*

ЗУСАГ угтаа хонь ямааны гурван настайн нэр, одоо шүдлэн эм хонь ямааг нэрлэдэг; *зусаг хонь; зусаг ямаа;* **зусаг зүр** (хөёр настай зүр).

ЗУСАР бялдууч, хүнд саймсран нийлүүлж мэхлэн аргадан явах зан ааш; **зусар бялдууч х о р ш .**

ЗУСАРДАХ хүнд бялдуучлан, зусар зан гаргаж явах.

ЗУСАРДУУЛАХ 1. зусардахын үйлдүүлэх хэв; 2. зусардагдах.

ЗУСАРЛАХ зусар зан гаргах.

ЗУСАРЧ бялдуучлан явдаг хүн; *зусарч хүн зулгаа бардаг, зуудаг нохой соёогоо бардаг.*

ЗУСАРЧЛАХ зусарч байх, зусарч байдал гаргах.

ЗУСАХ зуны цагийг туулан өнгөрүүлэх; *нутаглан сууж зусах; гэр хөрөнгөөр нүүдэллэн зусах; биеэр яван зорчин зусах.*

ЗУСЛАН хүмүүсийн зуны цаг буудаллаж намар хүртэл нутаглах газар нутаг; *зусланд гарах.*

ЗУСМАЛ зусаал; *зусмал хүчтэй.*

ЗУТААЛГАХ зутааахын үйлдүүлэх хэв; зугадуулах.

ЗУТААХ дутаах, буруулах.

ЗУТАН гурил будаа зэрэг зүйлийг өөх тосонд хольж хуураад, халуун цай сүү ус зэргийг хольж хийсэн шингэвтэр идээний нэр; *гурилын зутан; будааны зутан; зутан хийх.*

ЗУТАХ 1. зуд гачиг тохиож, идэш ууш тасрах, ховордох зэргээр мохож туйлдах; **зутах гутах х о р ш .**; 2. зүдэх, ядрах, доройтох.

ЗУТРАХ зуд гачигт хүн мал тохь алдаж зүдэх, гачигдах.

ЗУУ (Н) I 1. тооны нэр, ер дээр арвыг нэмсэн нь; *арван арав зуу; зуу хоногийн аялал; зуун тэмээ; зуун төгрөг; зуун хувь; ажлаа зуун хувиар биелүүлэв;* 2. цаг үе, нэг зуун жил; *хорьдугаар зуун;* **зуун мод** (ойгоос тасархай хэсэг бөөм мод); **зуун хоногийн ханиад** (ихэвчлэн хүүхдэд тусдаг, хөхүүлэн ханиалгах халдварт ханиад); **зуун овог** (хүн төрөлхтний овог төрөл маш олон тул хураангуйлан товчилж «зуун овог» гэж нэрлэжээ, даруй олон овог гэсэн үг мөн).

ЗУУ II 1. Буддын шашны ёсны бурхны нэр; *Зандан зуу;* 2. мөн бурхны шүтэж байгаа сүм хийд; *Эрдэнэ зуу; Баруун зуу.*

ЗУУВАЙЛГАХ зуувайхын үйлдүүлэх хэв, зуувгар болгох.

ЗУУВАЙХ зуувгар болох.

ЗУУВАН тойрсон хүрээлсэн бүюу өнцөггүй мөхлөг юмны яг дүгрэг биш үртлаг хэлтгий хэлбэр; *зууван толгойтой; зууван хэлбэртэй.*

ЗУУВАНДАХ хэтэрхий зууван болох.

ЗУУВАНДУУ арай зууван, баахан зууван.

ЗУУВАНДУУЛАХ зуувандахын үйлдүүлэх хэв.

ЗУУВАНДУУХАН арай зуувандуу, баахан зуувандуу.

ЗУУВАНЦАР зууванд төсөөтэй.

ЗУУВГАР зууван хэлбэртэй; *зууван шаазан; зуувгар хэлбэртэй сав.*

ЗУУВГАРДАХ хэтэрхий зуувгар болох.

ЗУУВГАРДУУ арай зуувгар, баахан зуувгар.

ЗУУВГАРДУУЛАХ зуувгардахын үйлдүүлэх хэв.

ЗУУВГАРХАН арай зуувгар, баахан зуувгар.

ЗУУГА услах шуудуу.

ЗУУГААД 1. зуу орчим; 2. тус бүр зуу.

ЗУУГДАХ 1. зуухын үйлдэгдэх хэв; 2. юмны завсар хавчуулагдах; *модонд хөрөө зуугдах.*

ЗУУДУГААР дэс дараалсан тооны зууд тохиолдсон нь; *зуудугаар зүйлд дурьдсан нь...*

ЗУУЗАЙ I хуучин, амгай төмрийн нэр байснаа эдүгээ хазаарын амгайвч холбох цагариг төмөрлөг; **амгай зуузай** хорш.; **зуузай холбох, зуузай зэрэгцэх** (уралдсан морь мал буюу нэгэн хамт яваа амьтны сацууран зэрэгцэж явах; *тавдахь морь зуузай холбон ирэв);* **зуузай зуулгах** (морь малыг унаж явахдаа жолоог баахан татасхийж явах).

ЗУУЗАЙ II гутлын өсгийн дотоодод хадах хатуу шир буюу ширмэл зүйлээр хийсэн нэгэн зүйл нөхөөс; *гутлын зуузай.*

ЗУУЗАЙ III алга; **алга зуузай** хорш.; *алга зуузай таших.*

ЗУУЗАЙЛАХ алга ташлах; *алга зуузайлах.* цах.

ЗУУЗУУ ямааг ирүүлэхээр дуудах аялга.

ЗУУЗУУЛАХ зуузуу гэж дуудах.

ЗУУЛГАХ 1. зуухын үйлдүүлэх хэв; 2. зуугдах; *нохойд зуулгах.*

ЗУУМАЛЗАХ хүний инээмсэглэх байдал гаргах.

ЗУУМАЛЗУУЛАХ зуумалзахын үйлдүүлэх хэв.

ЗУУМГАНАХ хүний инээмсэглэх байдал илрэх.

ЗУУМГАНУУЛАХ зуумганахын үйлдүүлэх хэв.

ЗУУМГАР нүх сүв, ам амсрын нарийн явцуу, зуувгар; жуумгар ч гэдэг.

ЗУУМГАРХАН арай зуумгар, баахан зуумгар.

ЗУУНТАА зуун удаа, зуу дахин.

ЗУУР 1. түр; *баахан зуур; түргэн зуур; агшин зуур;* 2. замд, хооронд, аливаа зорьсон заасан газар хүрээгүй; *зам зуур хоцров; эндээс тэнд хүртэл зуур хоногийн газар бий; ирж явах зуур тохиолдов; үзэх зуур худал хэлэв;* 3. гэртээ, дотроо; *гэр зуур өнжив; өвөр зууpаа хэрэглэв.*

ЗУУРАГДАХ зуурахын үйлдэгдэх хэв.

ЗУУРАЛДАХ 1. зуурахын үйлдэгдэх хэв; 2. юм хоорондоо авцалдах, хутгалдах, хольцолдох зэргээр авсаар салахгүй болох; *шавар нь зууралдаад байна; савтайгаа зууралдсан жонхуу;* 3. амьтан хоорондоо ноцолдож үргэлжлэн тэмцэлдэх; *нохой зууралдан хэрэлдэх; цэрэг зууралдан байлдах;* 4. үйл ажилд баригдах; *гэрийн ажилтай зууралдах; хүүхэд зууралдаад салдаггүй.*

ЗУУРАЛДУУЛАХ зууралдахын үйлдүүлэх хэв, зууралдахад хүргүүлэх.

ЗУУРАЛТ зуурсан нь.

ЗУУРАМ 1. дутуу, үйл ажил дуусварлаагүй дутуу дулим; *хийж байсан ажлаа зуурам зогсов;* **дутуу зуурам** хорш.; 2. цаг хэмжээ болоогүй буюу зорьсон хүссэндээ хүрээгүй; *зуурам хагацах; санасан нь зуурам болов;* 3. харвасан шидсэн зүйл заасан газарт хүрэхгүй зуур тусах; *шагааны сум зуурам унав.*

ЗУУРАМЛАХ зуурам болгох, зуурам хагацах.

ЗУУРАХ I нунтаг үйрмэг юманд шингэн юм хольж хутгаж найруулах, хавирах; *гурил зуурах; шавар зуурах; будаг зуурах; бэх зуурах; усаар зуурах; тосоор зуурах.*

ЗУУРАХ II 1. өвчин эмгэг, хор гэмээр шүд ба гар хөшиж ангайж нээгдэхгүй болох; *шүд зуурах; ам зуурах;* 2. хайч өрөлбө бахь зэргийн хазах хавчих юмны ангайхдаа гацах; *бахь зуурах;* 3. ямар нэгэн юм гацаж саатах; *цоож зуурах; хаалга зуурах;* 4. бариад үл тавих, салдаггүй; *гараас зуурах; хормойноос зуурах.*

ЗУУРД юмны туйл чанад хүрэхийн завсар хооронд; *зуурдаар үхэх; зуурдын саад бэрхшээл; зуурдын үхэл.*

ЗУУРМАГ I зуурам, хоёрын хооронд.

ЗУУРМАГ II зуурмал; *шаврын зуурмаг; шохойн зуурмаг;* 2. дутуу зуурам.

ЗУУРМАГЛАХ I үйл явдлыг дуусварлахгүй зуурам орхих, дутуу зуурам болгох.

ЗУУРМАГЛАХ II зуурах, зуурсан болох, багсрах.

ЗУУРМАЛ зуурсан юм; *зуурмал будаг; зуурмал шавар.*

ЗУУРУУЛ бэх будаг зуурах хэрэгсэл; *зуурууль сав; зуурууль мод.*

ЗУУРУУЛАХ 1. зуурахын үйлдүүлэх хэв; 2. зуурагдах.

ЗУУТ зуун тоо бүхий юм; *зуутын дарга; зуутын нэг;* **зуутын дэвсгэр** (зуун төгрөгтэй тэнцэх нэгт дэвсгэр мөнгө).

ЗУУХ I дотор нь гал түлэхэд тохируулан хийсэн тусгай хэрэгсэл; *төмөр зуух; шавар зуух; газар зуух.*

ЗУУХ II аливаа амьтны шүд амаар хазах: **нохой зуух** (нохой хазаж урах); **чоно зуух** (чоно хазаж урах); **хөмхий зуух** (а. дээд шүдээр доод уруулаа хазах; б. дургүйцэн үл тааламжлах байдал гаргах); **шазуур зуух, жазуур зуух** (а. дээд шүдээр аль нэгэн завжаа хазах; б. өшөө хонзон хадгалж занах); **шүд зуух** (а. шүдний уг этгээдээр чанга хазах; б. чийр зааж тэвчин тэсвэрлэж гарах; в. бусдад өшөө өвөрлөж хорсгол хадгалах); **явсан нохой яс зуух** (явбал олох); 2. өрөлбө хазуур зэрэг юмаар хавчих, чимхэх.

ЗУУХ III: **амь зуух, аж зуух ажил хөдөлмөр** хийж амиа тэжээх.

ЗУУХЛАХ юмыг зуух мэт эрэх, малтах; *худаг нүх зуухлах; мөс цасыг зуухлах; зуухалж малтах.*

ЗУУХЧ зуух хийхдээ чадамгай хүн; *зуухч хүн.*

ЗУУЦУУ ямаа ишгийг ир гэж дуудахад хэрэглэх аялга.

ЗУУЦУУЛАХ ямаа ишгийг зууцуу гэж дуудах.

ЗУУЧ I, хоёр этгээдийн хооронд нийлүүлэн зохицуулагч гуравдугаар этгээд; *зуучаар оролцуулах;* 2. ураг бололцоход завсар хэлэлцэх хүн; *зууч эмгэн.*

ЗУУЧЛАХ зууч болон хэлэлцэх.

ЗУУЧЛУУЛАХ зуучлахын үйлдүүлэх хэв.

ЗУУШ I хоол идэх буюу архи айраг уухын завсар амтлан идэх уухад зориулан базаасан мах ногооны зэрэг зүйл; *хоолны зууш; цайны зууш; хүйтэн зууш.*

ЗУУШ II аливаа юмны идэш, завшаан болох, ашиглагдах; **амны зууш** (муу нэр алдаршин олонд жигшигдэн хэлэлцэгдэх; *амны зууш болсон амьтан).*

ЗУУШЛАХ зууш болгон хэрэглэх.

ЗУУШЛУУЛАХ зуушлахын үйлдүүлэх хэв.

ЗҮВ: **зүв зүгээр** 1. огт гэмгүй, тухайлсан хэрэг зориггүй; *зүв зүгээр хэсч явна; зүв зүгээр суух;* 2. хүн амьтны бие эрүүл сайн, хэвийн байдалдаа; *бие зүв зүгээр байна;* 3. юмны яс чанар үзэмж байдал хэрэглэж болохуйц; *зүв зүгээр эд бололтой.*

ЗҮВЛЭХ: **дээл зүвлэх** дээлийн өнгө дотрыг тохируулан оёход бэлтгэх.

ЗҮВЧИХ амь бие хайргүй гүжирмэгээр явах, алга болох, дамжих.

ЗҮГ I орчлонгийн аливаа чиг, зүүн баруун, хойт, урдыг дөрвөн зүг гэх ба түүний завсрыг дөрвөн зовхис гэж, дээр дорыг нэмээд арван зүг гэнэ; **сарны зүрхайн ёсны хорин дөрвөн зүг, гурван зуун жаран зүг** гэх мэтээр хуваах ёс бас бий; **зүг чиг** х о р ш.; *дөрвөн зүг, найман зовхис; нар гарах зүг; нар шингэх зүг; зүгийн муу зүүн хойно* х у у ч.; **зүг зүг** (зүг бүрд; *зүг зүгээс ирэх; зүг зүгт тараах*); **зүг гаргах, зүг зүглэх** х у у ч и р с а н (цагаан сарын шинийн нэгний өдөр хүний өлзийтэй сайн зүгтээ чиглэх зан үйл).

ЗҮГ II зүгээр, энгийн, дэмий; *зүг ирлээ; зүг яваа гэнэ.*

ЗҮГГҮЙ I. огт зүгээр байдаггүй, саваагүй, дүрсгүй; *зүггүй хүүхэд зүггүй нохой;* 2. эх захгүй, эмх замбараагүй; *зүггүй их ажил юм; ажил гэж зүг байхгүй.*

ЗҮГГҮЙРХЭХ зүггүй зан ааш гаргах.

ЗҮГГҮЙТЭХ зүггүй зан байдал гаргах.

ЗҮГЛҮҮЛЭХ 1. зүглэхийн үйлдүүлэх хэв; 2. нэгэн тийш дөнгөж хандуулах; *ажил хийх ч гэж зүглүүлээд орхижээ.*

ЗҮГЛЭХ нэгэн зүгт зорьж гарах, хандах; *зүг зүглэх; ажилд зүглэх; хаяа зүглэж явна.*

ЗҮГШРҮҮЛЭХ зүгшрэхийн үйлдүүлэх хэв.

ЗҮГШРЭХ 1. хүн амьтны ажил эдлэгээнд сурч дадах; *ажилд зүгшрэх; ном уншиж зүгшрэх; тэргэнд морь зүгшрэх;* 2. хүн амьтан зохих зүг чигээ олох; *зам нь зүгширч байна.*

ЗҮГЭЭР I огт учир хэрэггүй, дэмий л, үтэл, энгийн; *зүгээр явна; зүгээр ирсэн.*

ЗҮГЭЭР II 1. хэрэгтэй, чанар сайтай; *зүгээр ном шүү; зүгээр харандаа;* 2. сайн, гэм хоргүй; *зүгээр хүн; зүгээр багш; гэмгүй зүгээр; цагаан идээ биенд зүгээр; миний бие зүгээр болсон;* 3. дэмий; *зүгээр суухаар зүлгэж суу з ү й р.*

ЗҮГЭЭР III үнэ төлбөргүй; *энэ номыг багш над зүгээр өгсөн юм.*

ЗҮГЭЭРГҮЙ 1. энгийн биш, дэмий биш; *зүгээргүй сайн морь;* 2. дүрсгүй, зальтай; *зүгээргүй сэргэлэн хүүхэд;* 3. эрхбиш учир холбогдолтой; *тэр хоёр лав зүгээргүй.*

ЗҮГЭЭРХЭН арай зүгээр, баахан зүгээр.

ЗҮДРҮҮ ядруу, дорой, зүдүү.

ЗҮДРҮҮЛЭХ зүдрэхийн үйлдүүлэх хэв, зүдрэхэд хүргүүлэх.

ЗҮДРЭЛ зүдэл, ядрал, зүдэрсэн нь; *зүдрэл үзсэн хүн.*

ЗҮДРЭЛТЭЙ зүдрэл ихтэй, зовлонтой, зүдрээтэй.

ЗҮДРЭХ хүн амьтны алжаан зүдэх нь: **ядрах зүдрэх** х о р ш.; *аян замдаа алжаан зүдэрсэн байлгүй дээ.*

ЗҮДРЭЭ зүдрэх үйлийн нэр, зүдрэх; *зүдрээ нь гараагүй байна.*

ЗҮДРЭЭХ зүдрэхэд хүргүүлэх; **зовоох зүдрээх** х о р ш.;

ЗҮДҮҮ 1. эд юм дутагдаж бие зовох; **ядуу зүдүү** х о р ш.; 2. өвчин эмгэг зэрэгт нэрвэгдэж бие доройтсон нь.

ЗҮДҮҮЛЭХ зүдэхийн үйлдүүлэх хэв.

ЗҮДҮҮР зүдэл зовол.

ЗҮДҮҮРТЭЙ халшралтай зовуурьтай явдал.

ЗҮДЭГ элэглэгдэх, шүүмжлэгдэх, жигшигдэх шившигтэй газар бий; *зүдэг хэрэг үйлдэж; инээж явах нь даан ч зүдэг.*

ЗҮДЭГДЭХ хэтэрхий зүдэг болох.

ЗҮДЭЛ зүдүүр зовол.

ЗҮДЭНГЭ бие дэмий л алжаангуутай, ядангги, дорой.

ЗҮДЭНГЭРЭХ алжаан дордох, доройтох.

ЗҮДЭР бузар, муухай, *зүдэр ус ууж болохгүй.*

ЗҮДЭРГЭХ зүдрүүлэх, зовоох.

ЗҮДЭРГЭЭ ядаргаа; *биенд зүдэргээтэй ажил.*

ЗҮДЭХ амьтны зовох, ядангирах.

ЗҮЙ 1. аливаа юмны тогтоол жам ёс ба түүнд тавтайяа нийлэлцэх; *зүй тогтоол; зүй зарчим; зүй ёс; зүй зохис; зүйн доторхи хэрэг; зүй бус ажил;* 2. ямар нэгэн сургаал, онол; *хэлний зүй; газрын зүй; арга зүй; авианы зүй; ном зүй;* **зүй зохис** (аяс, нийлэмж, боломж; *зүй зохисоор хуваах; зүй зохисыг үзэж ногдуулах*).

ЗҮЙГҮЙ зүй ёсонд нийлэхгүй, таарахгүй; *зүйгүй хэрэг; зүйгүй явдал.*

ЗҮЙДЭЛ зүйсэн нь; *дээлийн зүйдэл; малгайн зүйдэл; ширээний зүйдэл.*

ЗҮЙДЭЛГҮЙ зүйдэл ороогүй.

ЗҮЙДЭЛТЭЙ зүйдэл бүхий юм; *зүйдэлтэй үс; зүйдэлтэй ширээ.*

ЗҮЙЛ 1. ажил хэргийн салаа салбар; *энэ хэргийн доторхи зүйл маш олон; тэр ажлын дотроос тийм нэг зүйлийг би мэднэ; зүйл зүйлээр нь авч үзэх; зүйл зүйлийн хэрэг давхцах; зүйл дуусав; зүйл дуусгах;* 2. үйл явдлын учир ялгавар; *урьд чингэж байсан зүйл бий; хожим тийм зүйл гарахгүй биз; урьдах зүйл нь дараа зүйлтэй холбогдолгүй;* 3. юмны төрөл ялгал, анги аймаглал; *амьтны зүйл; тарианы зүйл; торгоны зүйл; аар саар зүйл; хэлэлцэх зүйл; зүйл бүр; зүйл зүйл; олон зүйл;* 4. бичиг номын үг утга, хэсэг бүлэг, аймаг үес; *хууль зүйл; тавдугаар зүйл; зүйл дараалан хянах; зүйлчлэн тодорхойлох;* 5. юм; *би чамд нэг зүйлийг хэлье; ийм зүйл над хэрэггүй; чингэж санасан зүйл байхгүй; өөр зүйл алга.*

ЗҮЙЛГЭХ зүйхийн үйлдүүлэх хэв, зүйхэд хүргүүлэх.

ЗҮЙЛЛҮҮЛЭХ зүйллэхийн үйлдүүлэх хэв.

ЗҮЙЛЛЭХ юмыг зүйл зүйлээр болгох.

ЗҮЙЛҮҮЛЭХ зүйлэхийн үйлдүүлэх хэв.

ЗҮЙЛЧЛҮҮЛЭХ зүйлчлэхийн үйлдүүлэх хэв.

ЗҮЙЛЧЛЭХ юмыг зүйл болгон дараалах.

ЗҮЙЛЭХ юмны үсийг хусч арилгах; *ширний үс зүйлэх;*

ЗҮЙМЭЛ олон хэсэг юмыг нийлүүлэн хийсэн нь; *зүймэл тооно; зүймэл ширээ.*

ЗҮЙР адилтгал, жишил; **зүйр үг** ардын аман зохиолын нэг зүйл, адилтган жишиж хэлсэн уламжлалт үг; *зүйргүй үг байдаггүй, зүйдэлгүй дээл байдаггүй* з ү й р.

ЗҮЙРГҮЙ үлгэрлэж адилтгашгүй; *зүйргүй их.*

ЗҮЙРЛҮҮЛЭХ зүйрлэхийн үйлдүүлэх хэв.

ЗҮЙРЛЭЛ зүйрлэх үйлийн нэр; зүйрлэсэн юм; *хэтрүүлсэн зүйрлэл; утга зохиолын зүйрлэл.*

ЗҮЙРЛЭХ ямар нэгэн юмыг өөр нэгэн юмтай жишиж адилтгах; *сайн юмтай зүйрлэх хэрэгтэй.*

ЗҮЙРЛЭШГҮЙ зэрэгцүүлшгүй, адилтгашгүй; *зүйрлэшгүй их.*

ЗҮЙТЭЙ зөвтэй, нийлэмжтэй, таарамжтай; *зүйтэй байна, батлая.*

ЗҮЙХ жижиг хэсэг юмыг нийлүүлэн нэгтгэж эвлүүлэх; *арьс зүйх; зүйж хадах; зүйж оёх.*

ЗҮЙЧ: газар зүйч газар зүй судлагч.

ЗҮЙЧЛҮҮЛЭХ зүйчлэхийн үйлдүүлэх хэв.

ЗҮЙЧЛЭХ юмны зүйгий нь эрэх, олох.

ЗҮЛГҮҮЛЭХ 1. зүлгэхийн үйлдүүлэх хэв; 2. зүлгэгдэх.

ЗҮЛГҮҮР 1. юмыг зүлгэж өнгийг гилгэр болгох хэрэглэл, өнгөлүүр ч гэдэг; *модны зүлгүүр; төмрийн зүлгүүр;* 2. шойз.

ЗҮЛГҮҮРДҮҮЛЭХ зүлгүүрдэхийн үйлдүүлэх хэв.

ЗҮЛГҮҮРДЭХ зүлгүүрээр зүлгэх; *шойзоор зүлгүүрдэх.*

ЗҮЛГЭГЧ зүлгэх үүрэгтэй хүн.

ЗҮЛГЭЛЭГ: зүлгэлэг цэцэг у р г а м а л усанд ургадаг, урт иштэй, хонгорцог навчлянхуа цэцгийн янзтай болдод жижигхэн, өнгө улаавтар цагаан, өдрийн наранд усан дээгүүр дэгдэнэ, шөнө усны ёроолд орно, сайхан үнэртэй.

ЗҮЛГЭНҮҮЛЭХ зүлгэнэхийн үйлдүүлэх хэв, зүлгэнэхэд хүргүүлэх.

ЗҮЛГЭНЭХ морь малыг зөөлхнөөр эдэлж баахан дасах.

ЗҮЛГЭХ юмыг зүлгүүр алчуур мэтээр хавиран билүүдэн арчих, зүлгүүрдэх; *ширээгээ зүлгэж арчив.*

ЗҮЛД 1. алсан малын толгой, багалзуур, уушиг зүрхийг үргэлж авсан нь; *зүлд авах;* 2. юмны гол болох зүйл; **гол зүлд х о р ш . .**

ЗҮЛДЛЭХ 1. алсан малын зүлд авах; 2. зүлд болох, голлох.

ЗҮЛМЭХ зэлмэх.

ЗҮЛЧГЭР ураг төрөлдөө элэгсэггүй, тоомсоргүй зантай.

ЗҮЛЧИЛЗЭХ зовниж нүүр улайх; нүүр *зүлчилзэх.*

ЗҮЛЭГ үргэлжилсэн өвс үндэстэй, төрөлхийн нойтон чийгтэй; **зүлэг ногоо, ширэг зүлэг х о р ш . ; зүлэг суулгах** (халцгай газар зүлэг дэвсч ургуулах).

ЗҮЛЭГДҮҮ арай зүлэгтэй, баахан зүлэгтэй.

ЗҮЛЭГДҮҮХЭН арай зүлэгдүү, баахан зүлэгдүү.

ЗҮЛЭГЖИХ зүлэгтэй болох.

ЗҮЛЭГЖҮҮЛЭХ зүлэгжихийн үйлдүүлэх хэв.

ЗҮЛЭГШИХ зүлгийн шинж орох, зүлэг бий болох.

ЗҮЛЭГШҮҮЛЭХ зүлэгшихийн үйлдүүлэх хэв.

ЗҮЛЭЭ дүүжингийн оосор торгох сэнж.

ЗҮР эм бор гөрөөс; *гүр зүр хоёр.*

ЗҮРГИЙ чөдөр өвс.

ЗҮРЖ жүрж.

ЗҮРМҮҮЛЭХ зүрмэхийн үйлдүүлэх хэв.

ЗҮРМЭХ юмыг жижиглэн зүрэм болгох.

ЗҮРХ 1. амьтны цусны эргэлтийн гол эрхтэн; *зүрхний гэм; зүрхний өвчин; зүрхний цохилт; зүрхний хэнээрэл;* **зүрхний тольт** (зүрхний язгуурын цагаан); **зүрх томрох** (зүрх нь хэвийн хэмжээнээс их болох); **зүрх хагарах, зүрх дэлбэрэх** (өнхөлцөг хагарах); **зүрх булгилах, зүрх түгших, зүрх цохих, зүрх дэлсэх, зүрх чичрэх, зүрх цохилох, зүрх догдлох** (зүрх долгисон хөдлөх, зүрхэн тус түг түг хийх); 2. зориг; **зүрх зориг** х о р ш.; **зүрх их** (зориг их бөгөөд айх шантрахгүй); **зүрх бага** (аймхай, халирамхай, хулчгар); **зүрх гаргах** (үйл явдалд зориг гаргах); **зүрх үхэх** (үйл ажилд зориг нь шантрах); **зүрх алдах** (айж бэрхшээх); **зүрх шантрах, зүрх мохох** (зориг харих); **зүрх муутай** (аймтгай): **зүрх орох** (зориг орох); **зүрх хүрэхгүй** (айн бэрхшээж, халдаж чадахгүй халирах); **зүрх шимшрэх, зүрх шижигнэх** (сэтгэлийн зовнилоор бэгтрэн доройтох, айж бэрхшээх); **зүрх эмтрэх; зүрх өвдөх** (сэтгэлийн зовлонгоор догор бэгтрэх); **зүрхэнд хүрэх** (а. тос өөх идэж шандуурах; б. зүрхэнд орох); **зүрхэнд орох** (айдаг болчихсон ямар нэгэн юмнаас жийрхэн зүрхших); 3. дотно, хайр; **гол зүрх; амин зүрх** (хамгийн хайртай); **үнэн зүрхнээс, зүрхний угаас, гол зүрхнээс, чин зүрхнээс** (үнэн санаанаас, чин сэтгэлээс, үнэн голоосоо); **зүрхний амраг** (хайртай амраг); **зүрхний нөхөр** (хамгийн дотно итгэлтэй нөхөр); *бөх зүрхтэй, будүүн голтой* з ү й р.

ЗҮРХГҮЙ аймтгай, зориггүй, шантрамтгай, хулчгар, уульхай моходог, няцах зогсох хялбар; *чамд хэлэх зүрх байхгүй;*

ЗҮРХЛҮҮЛЭХ зүрхлэхийн үйлдүүлэх хэв.

ЗҮРХЛЭХ зүрх зоригоо чангатган зориглох.

ЗҮРХТЭЙ 1. зоригтой, айдаггүй, зориг ихтэй; *их зүрхтэй; том зүрхтэй;* 2. тэнэг балмад.

ЗҮРХШИХ юмнаас айн бэгтэрч бэрхшээх.

ЗҮРХШҮҮЛЭХ зүрхшихийн үйлдүүлэх хэв.

ЗҮРХШЭЭХ баахан зүрхших.

ЗҮРХЭВС номин хулганын өөр нэр.

ЗҮРХЭВЧ I түргэн эгчис зантай хүн.

ЗҮРХЭВЧ II а м ь т а н хэрмийн намын хулгана, бие бяцхан, өнгө улаан шар цайвар хольцолдсон бөгөөд нуруу дагуу хар бор бидэртэй, модонд асах авирахдаа сайн, самар ба шилмүүст модны үр иднэ.

ЗҮРХЭВЧ III цахилгаан соронзны ороомгийн доторхи гол.

ЗҮРЭМ жижиглэсэн нарийн зүрвас юм; *махны зүрэм; модны зүрэм; цаасны зүрэм.*

ЗҮРЭМДЭГ зүрэмдэс.

ЗҮРЭМДЭГЛЭХ зүрэмдэг болгох.

ЗҮРЭМДЭС зүрэмлэсэн юмны нэг хэсэг буюу ширхэг; *махны зүрэмдэс; модны зүрэмдэс.*

ЗҮРЭМДЭСЛЭХ зүрэмдэс болгох.

ЗҮРЭМЛҮҮЛЭХ зүрэмлэхийн үйлдүүлэх хэв, зүрэм болгуулах.

ЗҮРЭМЛЭХ юмыг жижиг жижиг, нарийн зүрвас болгон хэсэглэх; *мах зүрэмлэх; мод зүрэмлэх.*

ЗҮРЭР жүрүр.

ЗҮС I хүний нүүрийн өнгө дүр ба амьтны өнгө; **өнгө зүс, зүс царай** х о р ш.; *сайхан зүс; муухай зүс; хар зүс; алаг зүс; хээр зүс;* **зүс хувирах** (юмны өнгө зүс өөр болох); **зүс улайх** (нүүр царай улайх, ичингүйрэх); **зүс үзэх** (нүүр царайгий нь харах; *урьд зүс үзсэн хүн билээ);* **зүс буруу** (зүс ижил биш, этгээд зүстэй, урьд үзээгүй зүстэй); **зүс хувилах** (хүн амьтны царай өнгө зэргийн өөр болон хувирч солигдох); **зүс хувилгах** (а. хүний биеийнхээ байдлыг өөрчлөх; б. юмыг сольж хувируулах).

ЗҮС II: **зүс бороо** зөөлөн бөгөөд удаан үргэлжлэн орох бороо; *зүүн хойноос үүлтэйхэн байна хөө, зүс бороо орох нь юм уу даа хөө* (ардын дуу).

ЗҮСГҮЙ царай муутай, өнгө муутай.

ЗҮСЛҮҮЛЭХ I. зүслэхийн үйлдүүлэх хэв; 2. зүслэгдэх.

ЗҮСЛЭГДЭХ зүслэхийн үйлдэгдэх хэв, зүслүүлэх.

ЗҮСЛЭХ 1. юмны өнгө зүсийг санаандаа ойлгож тогтоох, зүсээр нь ялгаж таних; *адуу зүслэх; хурга зүслэх;* 2. бусдад өгөх эд юмыг

оноож заах; *морь зүслэх; авдар зүслэх; зүсэлж авах; зүсэлж өгөх.*

ЗҮСМЭЛ зүсэж хийсэн юм; *зүсмэл банз; зүсмэл шал; зүсмэл унь.*

ЗҮСРЭХ зүс бороо орох; *бороо зүсрэв.*

ЗҮСТЭЙ зүс сайтай, өнгө сайтай, царай сайтай, жавхаатай, үзэмжтэй; *нэртэй хүний зүстэй хүү.*

ЗҮСҮҮЛЭХ зүсэхийн үйлдүүлэх хэв; зүсэгдэх.

ЗҮСҮҮР зүсдэг хэрэгсэл; *аарцны зүсүүр.*

ЗҮСЭГДЭХ зүсэхийн үйлдэгдэх хэв, зүсүүлэх.

ЗҮСЭМ I 1. малын өнгө зүс; *алаг зүсмийн морь;* 2. юмны биеэр нь; *зүсэм эд; зүсэм мал.*

ЗҮСЭМ II зүссэн юмны нэгэн хэсэг; *нэг зүсэм талх; зүсэм бяслаг.*

ЗҮСЭМНЭХ идэх идээний зүйлийг зүрмэлж зүсч хэсэглэх; *талх зүсэмнэх; бяслаг зүсэмнэх.*

ЗҮСЭХ 1. юмыг ирт зүйлээр хуваж салгах, хэсэглэх; *банз зүсэх; сүр зүсэх;* 2. бөөм буюу олон юмны дундуур нэгэн этгээдээс нөгөө этгээд хүртэл туулан гарах; *хотын дундуур зүсч гарах; зах дундуур зүсээд явчив; мөс зүсэх хөлөг онгоц.*

ЗҮТГҮҮЛЭХ зүтгэхийн үйлдүүлэх хэв, зүтгэхэд хүргүүлэх.

ЗҮТГҮҮР зүтгээ.

ЗҮТГЭЛ 1. юманд чармайх мэрийх; 2. бүтээл гавьяа; *бүтээл зүтгэл, гавьяа зүтгэл* хорш.

ЗҮТГЭЛТЭЙ зүтгэл сайтай; *зүтгэлтэй хүн.*

ЗҮТГЭЛТЭН нийгмийн үйл хэрэгт удирдах үүрэг гүйцэтгэгч, зүтгэгч хүн; *төрийн зүтгэлтэн, нийгмийн зүтгэлтэн; урлагийн гавьяат зүтгэлтэн.*

ЗҮТГЭЛЭГ зүтгэл; *зүтгэлэгтэй хүн.*

ЗҮТГЭМТГИЙ зүтгэдэг зантай, зүтгэмхий.

ЗҮТГЭХ 1. хүний үйл явдалд хичээл мэрийлт гаргах; *ажил хөдөлмөрт зүтгэх;* 2. юмыг хөдөлгөхийн төлөө тэмүүлэн хүч гаргах; *тэрэг чаргад зүтгэх; зүтгэх хүчин;* 3. хүний өөрийнхийгөө мөн зөв гэж хүчлэн маргах.

ЗҮТГЭЭ 1. хүний ямагт өөрийнхийгөө мөн зөв гэж чармайх маргах зантай; *зүтгээ хүн;* 2. морь малын хэтэрхий зүтгэдэг зантай; *зүтгээ морь; зүтгээ шар.*

ЗҮТГЭЭЧ зүтгэдэг амьтан.

ЗҮҮ (Н) I 1. юм оёход хэрэглэх утас сүвлэх сүвэгч бүхий нарийн төмөрлөг; **зүү хуруувч, зүү утас** хорш.; 2. оньсон хөдөлгүүр зүйлийн хөдөлгөөн хэмийг заах хэрэгсэл; *цагийн зүү; амьсгааны зүү;* 3. шивэх, хатгах, зүүх, торгох зэрэгт зориулан хийсэн хэрэгсэл; *бичгийн зүү; энгэрийн зүү; тарианы зүү;* **зүү ороох** (нэгэн зүйл оёдлын нэр; утсаар хээ угалз хатгамлахад даруулах утсыг зүүнд сувлээд дэвсгэрт хатгаж, угалз тавих утсыг зүүний үзүүрийг ороож даруулан оёх); **зүү тавих** (зүүгээр хатгаж эмчлэх); **зүү сүвлэх** (зүүний сүвэгчид утас дүрэх); **зүүний сүвэгч** (зүүний утас сүвлэх нүх); **зүүний хулгайч** ургамал (иш нарийн, түрүү хонгор зулын түрүүд төстэй бөгөөд бяцхан, түүний нарийн унгарил агаарт дэгдэг нэгэн зүйл ургамал); **зүү орох зайгүй** (маш дотно).

ЗҮҮ II лавдлан сануулах үгний дараа хэрэглэх аялга үг; *миний захисныг бүү мартаарай зүү;* **заа зүү болох** (яг таг тохиролцох; *тэр бид хоёр маргааш уулзана гэж заа зүү болов).*

ЗҮҮВЧ зүү агуулах савны нэр, дүр байдал олон янз.

ЗҮҮГДЭХ зүүхийн үйлдэгдэх хэв, авсаар салахгүй зүүх.

ЗҮҮД унтсан нойрын дундуур зөгнөгдөн сэрэгдэх зүйл, амах зүдэх, баясах, гомдох, үйлдэх, өгүүлэх зэргийн зөгнөгдөл цөм бий; *зүүдэнд орох;* **зүүд евчин** (унтсан нойрын дундуур зүүдлэн явж аливаа зүйл үйлдэх зэргээр аашлах өвчин).

ЗҮҮДЛЭХ зүүдэнд зөгнөгдөх; *урд шөнө их сайхан зүүд зүүдлэв.*

ЗҮҮЛГЭХ 1. зүүхийн үйлдүүлэх хэв, зүүхэд хүргүүлэх; 2. зүүгдэх.

ЗҮҮЛДЭХ зууралдах, чангаалдах.

ЗҮҮЛТ 1. зүүх чимэг хэрэглэлийн нэр; *энгэрийн зүүлт; ташааны зүүлт;* 2. бичиг номын дотор орсон зарим үг утгыг тусгайлан тайлбарласан тайлбар; *бичгийн зүүлт; түүний тайлбар нь дараах зүүлтэд бий.*

ЗҮҮЛЛҮҮЛЭХ зүүлэх II-ын үйлдүүлэх хэв.

ЗҮҮЛЭХ I зүүдлэх.

ЗҮҮЛЭХ II зүүн тийш явах, зорчих.

ЗҮҮН I 1. нар гарах дорнод зүг; *зүүн зүг; зүүн өмнө; зүүн хойш; зүүн тийш;* 2. урсгал усны ба хүн амьтны биеийн солгой гар тал; *зүүн эрэг дээр; зүүн гар; зүүн тал; зүүн гэр;* **зүүн өмнө** (зүүн ба өмнө зүгийн хоорондох зовхис чиг); **зүүн хойт** (умар ба зүүн зүгийн хоорондох зовхис чиг); **зүүн тийш** (а. зүүн зүг хандах; б. зүүн этгээд).

ЗҮҮН II улс төрийн урсгал; *зүүн үзэлтэн; зүүн жигүүр; зүүний нугалаа; зүүний хэлбэрэл.*

ЗҮҮРМЭГ I жил дараалан хүүхэд төрүүлдэг эхнэр; *зүүрмэг эмэгтэй.*

ЗҮҮРМЭГ II 1. түр зуур унтасхийгээд дутуу сэрсэн нь; *хүүхэд зүүрмэг болоод уйлагнаж байна;* 2. нойрмог байдалтай; *зүүрмэг хүн.*

ЗҮҮРМЭГЛҮҮЛЭХ зүүрмэглэхийн үйлдүүлэх хэв.

ЗҮҮРМЭГЛЭХ баахан зуур унтасхийх; *би дөнгөж зүүрмэглээд сэрэв.*

ЗҮҮТГЭЛ зүүдэг хэрэглэл.

ЗҮҮХ 1. юмыг юманд өлгөх, дүүжлэх, уях, углах, хадах зэргээр торгоож тогтоох; *тэмдэг зүүх; бөгж зүүх; пайз зүүх; сэтэр зангиа зүүх; дөнгө зүүх; зэрэг зүүх; буу зүүх;* 2. зуурах, чангаах; *манай хүүхэд надаас зүүгээд ер салдаггүй шүү.*

ЗҮҮЦЭЛДЭХ харилцан зүүлдэх.

ЗҮҮЦЭХ зүүх, зүүцэлдэх.

ЗҮХЛЭГ бусдыг хараж занах үг.

ЗҮХҮҮЛЭХ зүхэхийн үйлдүүлэх хэв, зүхэхэд хүргүүлэх.

ЗҮХЭГДЭХ зүхэхийн үйлдэгдэх хэв, зүхүүлэх.

ЗҮХЭЛ занал, хараал; **занал зүхэл, хараал зүхэл** х о р ш..

ЗҮХЭХ бусдыг муу болог гэж занан хараах; **хараах зүхэх, занах зүхэх** х о р ш..

ЗҮЧИХ зөрөх, зөрчих, хэвцэглэх.

ЗҮЧҮҮ нийцгүй, харилцан сарниу.

ЗҮЧЭЭ морь малыг хорих, хоргоох газар; *адууны зүчээ.*

ЗЭВ I байлдах гөрөөлөхөд хэрэглэх хоёр талдаа иртэй зэвсгийн нэр; **сумны зэв, мэс зэв** х о р ш..

ЗЭВ II 1. төмөрлөгийн зүйл агаарт исэлдэж гарсан улбар хүрэн хаг; *төмрийн зэв; зэв идэх;* 2. төмөрлөгийн бал; **бал зэв** х о р ш.; *зэсийн зэв; гуулины зэв;* 3 зэв балын амг; *төмрийн зэв амтагдах; юманд зэв орох;* **зэвийн чулуу** (будах ба зурахад хэрэглэх нэгэн зүйл чулууны нэр, **өнгө** хүрэн улаан).

ЗЭВЛЭХ юмны зэвийг арилгах.

ЗЭВРҮҮЛЭХ зэврэхийн үйлдүүлэх хэв.

ЗЭВРҮҮН асар тасхийм биш боловч баахан хүйтэн; *энэ өдөр нилээд зэврүүн байна.*

ЗЭВРҮҮХЭН арай зэврүүн, баахан зэврүүн.

ЗЭВРЭХ I төмөрлөгийн зүйлд зэв тогтох.

ЗЭВРЭХ II зэврүүн хүйтэн байдалтай болох.

ЗЭВРЭЭХ зэврэхэд хүргүүлэх, зэврүүлэх.

ЗЭВСЭГ хэрэглэх элдэв хэрэгсэл юм; 1. довтлох ба хамгаалахад чухал хэрэгцээтэй хэрэгсэл; **зэр зэвсэг, буу зэвсэг, зэвсэг техник** х о р ш.; *зэвсгийн нярав; зэвсгийн склад;* **халуун зэвсэг** (их буу, гар буу зэрэг галт зэвсэг); **галт зэвсэг** (буу, пуужин зэрэг); **хүйтэн зэвсэг** (хутга, сэлэм зэрэг мэсийн зүйлс); **зэвсгээ хураалгах** (багаж зэвсгээ өөр этгээдэд өгөх); **цөмийн зэвсэг** (атом, устөрөгчөөр хийсэн зэвсэг); 2. аливаа үйл ажилд хэрэглэх багаж хэрэглэл; **сав зэвсэг** х о р ш.; *дархны зэвсэг; тариалангийн багаж зэвсэг;* **чулуун зэвсэг** (эрт дээр цагийн хүмүүсийн хэрэглэж байсан чулуун багаж; *хуучин чулуун зэвсэг; шинэ чулуун зэвсэг);* **хүрэл зэвсэг** (эрт дээр цагийн хүмүүсийн хүрлээр хийсэн хөдөлмөрийн багаж); **төмөр зэвсэг** (эрт дээр цагийн хүмүүсийн төмрөөр хийсэн хөдөлмөрийн багаж); ☆ **хөгжмийн зэвсэг** (бүх төрлийн хөгжмүүд); **зэвсэг нэгтэй нөхөд** (мэрэгжил ба ажлаар адил хүмүүс); **үзэл суртлын зэвсэг** (үзэл суртлын хэрэглэгдэхүүн).

ЗЭВСЭГГҮЙ багаж хэрэгсэл юмгүй, гар мухар.

ЗЭВСЭГЖИХ зэвсэгтэй болох.

ЗЭВСЭГЖҮҮЛЭХ зэвсэгжихийн үйлдүүлэх хэв, зэвсэгтэй болгох.

ЗЭВСЭГЛҮҮЛЭХ зэвсэглэхийн үйлдүүлэх хэв, зэвсэгтэй болгох.

ЗЭВСЭГЛЭЛ зэвсэглэх үйлийн нэр, цэргийн бүх төрлийн зэр зэвсгийн хангамж; *зэвсэглэлийг хорогдуулах.*

ЗЭВСЭГЛЭХ 1. аливаа цэргийн зэвсэг хэрэглэлээ өмсөх, зүүх, барих; *орчин цагийн боловсон техникээр зэвсэглэх;* 2. ямар нэгэн сурлага мэрэгжил сайжирч боловсрох; *марксизмаар зэвсэглэх;* 3. ямар нэгэн зүйлд хэрэглэх

багаж хэрэглэлтэй болох; *дархны багажаар зэвсэглэх.*

ЗЭВСЭГТ зэвсэг бүхий; *зэвсэгт цэрэг;* **зэвсэгт хүчин** (аливаа нэгэн улс гүрний хуурай усан, агаарын замын цэрэг хийгээд бусад цэргийн холбогдох байгууллагуудын нийлбэр); **зэвсэгт бослого** (ноёлох ангийн эсрэг олноороо зэвсэг барьж тэмцэн боссон үймээн).

ЗЭВТЭХ юманд зэв тогтох, зэвтэй болох, зэврэх.

ЗЭВҮҮ дургүй, жигшил, эгдүүцэл; **зэвүү хүрэх** (юмыг жигшин үзэх буюу баахан дургүй болох, зэвүүцэх).

ЗЭВҮҮН ямар нэгэн юмны байдал төлөв айж сүрдэм буюу жигшмээр, сэжиглэмээр; *зэвүүн царайтай амьтан; зэвүүн санагдаж байна.*

ЗЭВҮҮРХҮҮ зэвүүхэн.

ЗЭВҮҮРХЭГ арай зэвүүрхүү, баахан зэвүүрхүү.

ЗЭВҮҮРХЭЛТЭЙ жигшүүрхэлтэй, дур гутмаар.

ЗЭВҮҮРХЭХ зэвүүцэх, зэвүү хүрэх, дур гутах, дургүй хүрэх; *гэрт тамхи татахаар чинь өвгөн их зэвүүрхэж байна билээ.*

ЗЭВҮҮХЭН арай зэвүүн, баахан зэвүүн.

ЗЭВҮҮЦҮҮЛЭХ зэвүүцэхийн үйлдүүлэх хэв, зэвүүцэхэд хүргүүлэх, зэвүүгий нь хүргэх.

ЗЭВҮҮЦЭХ зэвүүн юмнаас айх, жигших, дургүй нь хүрэх; *хэлэхээсээ зэвүүцэх; нүүрий нь харахаас зэвүүцэх; идэх гэхээс зэвүүцэх.*

ЗЭВЭГ зэвээ.

ЗЭВЭР ховор; **ховор зэвэр** х о р ш.; *энэ хавар ч баахан ховор зэвэр байх шиг байна.*

ЗЭВЭРГЭН баахан зэврүүн.

ЗЭВЭЭ а м ь т а н дорно зүгийн гол нуурууд дад орших, бие томтой нэг зүйл загас, авлаж хэрэглэнэ.

ЗЭГЗГЭР амьтны бие нарийвтар бөгөөд өндөрхөн; *зэрзгэр нуруутай хүн.*

ЗЭГС (ЭН) у р г а м а л усанд ургана, уг нь цагаан, навч нь урт бэгэвд хавтгай, өсөх сайн, чийрсний зэрэг юм хийнэ; *зэгсэн шүгүй.*

ЗЭГСЭН овоо сайн, олигтой; *зэгсэн морь; зэгсэн эд.*

ЗЭГСЧ шоргоолжин бялзуухайн өөр нэр.

ЗЭГЭХ санаа гүйцэх, ханах, цадах; *хоол идэж зэгэв; юм үзэж зэгэв.*

ЗЭД шашны ёсны хурлын лам нарт барих барьц; **зэд пог** х о р ш..

ЗЭДЛҮҮЛЭХ зэдлэхийн үйлдүүлэх хэв.

ЗЭДЛЭХ бусдад зэд юм түгээн тарааж өгөх.

ЗЭЛ 1. дээс сур зэргийг газарт сунган татаж хоёр үзүүрийг бэхэлсэн, мал уях хэрэглэлийн нэр; *тугалын зэл; унаганы зэл; гүүний зэл;* 2. тарвас гуагийн зэрэг зарим ургамлын иш нь зэлийн адил газраас хөндийрэхгүй ургах тул ийнхүү нэрлэнэ; 3. юм хум өлгөх хэц.

ЗЭЛГЭЭН I бүлээн; *зэлгээн цай; зэлгээн хоол.*

ЗЭЛГЭЭН II асар бүдүүнгүй бөгөөд хэрэглэхэд тохиромжтой юм; *зэлгээн уурга; зэлгээн үнь.*

ЗЭЛЛҮҮЛЭХ зэллэхийн үйлдүүлэх хэв.

ЗЭЛЛЭХ 1. зэлд мал уях зэл татах; *тугалаа зэллээд уя!;* 2. ногоо ургамлын зэлийн адил ургах; *гуа зэллэж ургадаг;* 3. юм хумыг хэц дээр өлгөх; *үгаасан юмаа зэллэж тавиад хатаа!* **зэллэн нисэх** (шувуу эгнэн нисэх).

ЗЭЛМҮҮР зэлмэх нь; *өлөн зэлмүүр.*

ЗЭЛМЭХ хоол унд арайхийн өллөхийн төдий идэх уух; *гол зэлмэх; өл зэлмэх.*

ЗЭЛҮҮД 1. хүн амьтангүй сэлүүн газар; *зэлүүд нутаг;* 2. хөдөө хээр, эзгүй газар; *зэлүүд тал.*

ЗЭЛҮҮДХЭН арай зэлүүд, баахан зэлүүд.

ЗЭЛХЭН бэлэн, бэлхэн; **бэлхэн зэлхэн** х о р ш..

ЗЭЛЭМ х у у ч и р с а н тайхад бургасанд уях цаасны зурвас.

ЗЭЛЭН бэлэн; **бэлэн зэлэн** х о р ш.; *бэлэн зэлэн юу байна, идэж уугаад явъя.*

ЗЭМ гэм, буруу; **гэм зэм, зэм буруу** х о р ш.; *гэм зэмгүй зүгээр гарав.*

ЗЭМГҮЙ 1. гэмгүй, буруугүй; 2. зүгээр, яах вэ.

ЗЭМДЭГ дутуу хагас; *хагас зэмдэг; эрэмдэг зэмдэг; дутуу зэмдэг; сэг зэмдэг.*

ЗЭМДЭГЛҮҮЛЭХ зэмдэглэхийн үйлдүүлэх хэв; *түүнд өгч зэмдэглүүлснээс байсан нь дээр.*

ЗЭМДЭГЛЭХ юмыг дутуу зэмдэг болгох; *зэмдэглээд орхих.*

ЗЭМДЭГРЭХ зэмдэг дутуу болох; *авах хэрэглэхийн аргагүй зэмдэг болох.*

ЗЭМЛҮҮЛЭХ 1. зэмлэхийн үйлдүүлэх хэв; 2. зэмлэгдэх; *би даргад зэмлүүлж зэмлүүлж ирэв.*

ЗЭМЛЭГДЭХ зэмлэхийн үйлдэгдэх хэв, зэмлүүлэх.

ЗЭМЛЭЛ эндэгдэн явсныг гаргасан буруушаал; **ял зэмлэл** х о р ш.; *зэмлэл хүлээх; зэмлэл хүлээлгэх.*

ЗЭМЛЭХ эндэгдэн явсныг заан гаргаж буруушаах; *хэлж зэмлэх; багш намайг сүрхий зэмлэв.*

ЗЭМС мал алсан хүн буюу гэдэс дотрыг цэвэрлэн ажилласан хүний мах гэдэс зүйлээс өөрт авах хувь; *зэмс авах; зэмс өгөх.*

ЗЭМСЭГ 1. хазаар худраганы бүх төмөрлөг чимэг; *хазаарын зэмсэг;* 2. эхнэр хүний хээ хэргэсэл ба хэт хутга зэрэг юманд гоёмсоглон үйлдсэн зүйл; *толгойн зэмсэг; хутганы зэмсэг;* 3. цэргийн зэвсэг; *зэр зэмсэг.*

ЗЭНДМЭНЭ чандмань.

ЗЭНДЭХ 1. айж бэмбэгнэх, сандрах тэвдэх; *айж зэндэхийн хэрэг юун;* 2. аюул осол болох, осолтой байдалд орох.

ЗЭНЗГЭНЭХ зэнзгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ЗЭНЗГЭР бие гуалиг цэвэр буюу ааль төлөв хээнцэр янзлаг; *зэнзгэр эмэгтэй; зэнзгэр хар хүн.*

ЗЭНЗГЭРДҮҮ зэнзгэр байдалтай.

ЗЭНЗГЭРХЭН арай зэнзгэр, баахан зэнзгэр.

ЗЭНЗИЙЛГЭХ зэнзийхийн үйлдүүлэх хэв, зэнзгэр болгох.

ЗЭНЗИЙХ зэнзгэр болох.

ЗЭНЗЭЛЗҮҮЛЭХ зэнзэлзэхийн үйлдүүлэх хэв.

ЗЭНЗЭЛЗЭХ зэнзгэр юмны байн байн хөдлөх.

ЗЭНТГЭР зантгар, занхгар.

ЗЭНТЭЛЗЭХ занталзах, занхалзах.

ЗЭНХГЭР зантгар, занхгар.

ЗЭНХЭЛЗЭХ занталзах, зэнтэлзэх.

ЗЭР: зэр зэвсэг зэвсэг техникийн нийт нэр.

ЗЭРГЭД хоорондоо тэнцүү хэмжээтэй, үл солбицох тууш хоёр шугам, паралель.

ЗЭРГЭЛ х у у ч и р с а н хоёр давхар, зэрэгцүүлсэн нь; *зэргэл ял ногдуулах; зэргэл авах.*

ЗЭРГЭЛДЭХ зэрэгцэх, зэрэглэх.

ЗЭРГЭЛДЭЭ зэрэгцээ, ойролцоо; *айл зэргэлдээ орон нутаг; зэргэлдээ гэр хашаа; нас уе зэргэлдээ.*

ЗЭРГЭЭР 1. цаг хэмийн сацуу; *нэгэн зэргээр цугларав; хэдэн зэргээр хэлэлцэв;* 2. тэргүүтэн; *бичих үнших зэргээр суралцах; хэлэлцэх захиалах зэргээр харилцах;... гэх зэргээр ярьж байна;* 3. бололцох жишээгээр; *чадах зэргээр гүйцэтгэх; хүрэлцэх зэргээр хэрэглэх.*

ЗЭРЛЭГ 1. хүнд дасаагүй, хээрийн долгин амьтад; *зэрлэг араатан; зэрлэг үхэр;* 2. хүн амьтангүй хээр хөдөө газар; *зэрлэг уул тал;* 3. хээр хөдөө ургадаг ургамал; *зэрлэг сонгино; зэрлэг олс;* 4. ногдсон эзэнгүй зарим зүйл; *зэрлэг сум; зэрлэг зэв;* 5. ёс журамгүй, балмад танхай байдал; *зэрлэг зантай; зэрлэг балмад хүн;* **зэрлэг олс** у р г а м а л (хээр ургана, салаа навч олсны адил, дурсыг салгаж боловсруулан ашиглана); **зэрлэг үзэм** у р г а м а л (шавтал модонд адил нэг зүйл модноос мойл адил хонгорцоглон ургадаг жимс, амт амтайхан); **зэрлэг өвс** (тариалангийн талбайд ургасан хээрийн өвс); **зэрлэг түүх** (тариалангийн газар ургасан зэрлэг өвсийг түүх).

ЗЭРЛЭГЛЭХ 1. хүүрийг хээр далд оршуулах; 2. тэжээврийн мал эзний гараас холдож хөдөө хээр газар удтал явж хүнээс үргэмтгэй болох.

ЗЭРЛЭГШИЛ зэрлэгших үйлийн нэр.

ЗЭРЛЭГШИХ гэрийн тэжээвэр амьтад хээр газар удтал оршин идээшиж зэрлэг байдалтай болох.

ЗЭРЛЭГШҮҮЛЭХ зэрлэгшихийн үйлдүүлэх хэв, зэрлэг шинжтэй болгох.

ЗЭРМИЙЛГЭХ зэрмийхийн үйлдүүлэх хэв, зэрэмгэр болгох.

ЗЭРМИЙХ зэрэмгэр болох.

ЗЭРМЭГНЭХ зэрэмгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ЗЭРМЭГХЭН хальт мөлтхөн; *зэрмэгхэн харахад.*

ЗЭРМЭЛЗЭХ зэрэмгэр юмны байн байн хөдлөх.

ЗЭРТГЭНЭХ зэртгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ЗЭРТГЭР 1. охидын жарвалзуур ааль байдалтай; 2. амьтны чих дээш бөгөөд хөнгөн хөдөлгөөнтэй; *зэртгэр чихтэй морь.*

ЗЭРТГЭРХЭН арай зэртгэр, бааханзэртгэр.

ЗЭРТИЙХ зэртгэр болох.

ЗЭРТЭЛЗЭХ зэртгэр юмны байн байн хөдлөх.

ЗЭРЭГ I 1. эрдмийн цол; эрдмийн зэрэг олгох; *дэд эрдэмтэн зэрэг авах; докторын зэрэг хамгаалах;* **зэрэг хамгаалах зохион** (эрдмийн зэрэг авахыг горилон бичсэн эрдэм шинжилгээний зохион); 2. хэргэм цол; *тэргүүн зэрэг тайж; гүнгийн зэрэг олгох; зэрэг дэвшүүлэх; зэрэг бууруулах;* 3. юмны дэс дараа, дэв дугаар;. *нэгдүгээр зэргийн гурил; тэргүүн зэргийн тамхи;* **зэрэг дугаар, зэрэг дэс; зэрэг дараа** х о р ш . .

ЗЭРЭГ II хам цуг; цаг үе адил сацуу; *бид нэг зэрэг яваад зэрэг ирсэн; хоолоо зэрэг идцээсэн;* 2. тэргүүтэн, төлөөлөн хамтатгасан нь; *хус улиас зэрэг навчит мод; торго бөс зэрэг эд бараа; ах дүүгийн зэрэг төрөл садан;* 3. хир хэмжээ, чанар байдал; *бичиг үсэг дунд зэрэг мэднэ; бага зэрэг ажил хийж байна; юм хир зэрэг мэдэх вэ? ямар зэрэг хүн бэ?;* 4. удаа дараа; *би нэгэн зэрэг айраг уулцав; хэдэн зэрэг учирсан;* 5. даруйд, үед; *бидний очихтой зэрэг ажил хийж эхлэв; бидний суухтай зэрэг л хурал эхлэв.*

ЗЭРЭГЛҮҮЛЭХ зэрэглэхийн үйлдүүлэх хэв. зэрэгцүүлэх.

ЗЭРЭГЛЭХ I сацууран зэрэгцэх, зэрэгцээ болох; *жагсаал зэрэглэх; зэрэглэж явах.*

ЗЭРЭГЛЭХ II юмыг жигдрүүлэн өрөх тавих; *аргал зэрэглэх; түлээ зэрэглэх.*

ЗЭРЭГЛЭХ III 1. гэрлийн эсрэг харахад зэргээтэх; *нүд зэрэглэх;* 2. аливаа гэрлийн гялбалзах; *гэрэл зэрэглэх.*

ЗЭРЭГЛЭЭ I зэргэлдээ; *зэрэглээ айл; зэрэглээ хашаа.*

ЗЭРЭГЛЭЭ II зэрэглээн; *зэрэглээ татах; талын зэрэглээ;* **зүүд зэрэглээ шиг** (а. нарийн туяа муутай; б. бүр түр балархай).

ЗЭРЭГЛЭЭН алсаас үзэхэд усны ар адил сэгүй зэрэглэн үзэгдэх газрын уур; *говь газрын зэрэглээн хот суурин шиг харагдана; зэрэглээн татах.*

ЗЭРЭГЛЭЭТҮҮЛЭХ зэрэглээтэхийн үйлдүүлэх хэв.

ЗЭРЭГЛЭЭТЭХ зэрэглэн үзэгдэх, зэрэглээтэн харагдах.

ЗЭРЭГЦҮҮЛЭХ зэрэгцэхийн үйлдүүлэх хэв, зэрэгцээ болгох.

ЗЭРЭГЦЭХ юмны зэрэгцээ болох; *зэрэгцэн явах; зэрэгцэж байгаад харахгүй бол харагдахгүй шүү.*

ЗЭРЭГЦЭЭ урьд хожид, өндөр нам, их багын зэрэг солиу гажуугүй жигд зэргэлдээ юм; *зэрэгцээ байшин; зэрэгцээ гэр; зэрэгцээ уул; зэрэгцээ хаалга.*

ЗЭРЭГЦЭЭГЭЭР зэрэг, сацуугаар, хажуугаар; *түүний зэрэгцээгээр; явахын зэрэгцээгээр.*

ЗЭРЭМГЭР аньсга нарийн; *зэрэмгэр нүдтэй;* зэртгэр ч гэнэ.

ЗЭРЭМГЭРДҮҮ зэрэмгэр байдалтай.

ЗЭРЭМГЭРХЭН арай зэрэмгэр, бааханзэрэмгэр.

ЗЭРЭМДЭГ дутуу зэмдэг; *эрэмдэг зэрэмдэг; дутуу зэрэмдэг; хагас зэрэмдэг.*

ЗЭРЭМДЭГЛҮҮЛЭХ зэрэмдэглэхийн үйлдүүлэх хэв, зэрэмдэг болгуулах.

ЗЭРЭМДЭГЛЭХ дутуу зэрэмдэг болгох.

ЗЭС I бодисын язгуурын махбодийн нэг; улаан өнгөтэй; давтамтгай нугарамтгай чанартай нэгэн зүйл төмөрлөг, ерийн зэс аранзан зэс гэж хоёр зүйл байдаг, аранзан зэс гэдэг нь хамгийн дээд зэргийн зэс, улаан алт ч гэж нэрлэх нь бий; *зэсийн хүдэр; зэсийн байван;* **зэс нь бултайх, зэс нь цухуйх** (хүний муу буруу үйл ажил бусад юмаар дамжиж өчүүхэн төдий илрэх).

ЗЭС II у р г а м а л нэг наст идэшний ногоо, нил ягаан өнгөтэй, өргөст хэмхээс арай том.

ЗЭСЛЭХ юмыг зэсээр бүрэх, бэхлэх.

ЗЭСҮҮЛ засуул, засуулч; *бөхийн зэсүүл; зэсүүл элч.*

ЗЭСҮҮЛЧ засуулч, жишүүлч.

ЗЭСЧ зэсийн дархан.

ЗЭСЭХ засах, жиших; *бөх зэсэх; өртөө зэсэх.*

ЗЭТГЭНЭ у р г а м а л саргай цэцгийн язгуурын олон наст ургамал, жимсгэнэ нь жижгэвтэр, зэтгэнээр чанамал хийхээс гадна архи нэрнэ.

ЗЭТГЭР үйл явдалд саад хор болох зүйл; **гай зэтгэр** х о р ш.; *ажилд зэтгэр битгий хий!*

ЗЭТГЭРДЭХ 1. зэтгэр болох, саад тотгор болох; 2. түйдэх, бузарлах.

ЗЭТГЭРЛЭХ 1. тотгорлох, юманд хор саад учруулах; 2. түйтгэрэх, бузардуулах.

ЗЭТГЭХ 1. үйл ажилд мэрийх, мэтгэх; *үйл зэтгэх; дээл зэтгэж оёх;* 2. ус гатлах; *ус зэтгэж гарав;* 3. сэтгэх; *суваг шуудуу зэтгэх.*

ЗЭТЭР хүний гар хөлийн хумсны угийн арьсны нийлэлт газар, зэт ч гэнэ; *зэтэр сөрөөд хуруу хөндуурлээд байна.*

ЗЭХИЙ аливаа юмны нөгөөгөөсөө дутуу буюу барагтайхан, муухан; *зэхий хүн; зэхий эд; зэхий ядуу.*

ЗЭХИЙВТЭР баахан зэхий мэт.

ЗЭХИЙВЭР арай зэхий, баахан зэхий.

ЗЭХИЙДЭХ хэтэрхий зэхий болох.

ЗЭХИЙЛЭХ зэхий зан байдал гаргах.

ЗЭХИЙРЭХ зэхий болох.

ЗЭХИЙТЭХ зэхий байдал гаргах.

ЗЭХИЙХ зэхий болох.

ЗЭХИЙХЭН арай зэхий, баахан зэхий.

ЗЭХРҮҮН жихүүн.

ЗЭХРҮҮХЭН жихүүхэн.

ЗЭХЭХ хэрэглэх юмыг урьдаас бэлтгэж бэлэн зэлэн болгох; **бэлдэх зэхэх** х о р ш.: *явах ажлаа зэхэж байна; унаа малаа зэхэв.*

ЗЭХЭЭ бэлэн, бэлхэн; *зэхээ морь.*

ЗЭХЭЭС бэлэн, бэлхэн, зэхээ.

ЗЭХЭЭСТЭЙ бэлэн байгаа, бэлхэн байгаа.

ЗЭХЭЭТЭЙ зэхээстэй, бэлэн, бэлхэн.

ЗЭЭ I бусдын хэлснийг хүлээн зөвшөөрөхөд хэрэглэх аялга үг; *зээ мэдлээ; зээ, би мартахгүй;* **зээ царцаахай** а м ь т а н (тарианы үр идэг нэгэн зүйл хорхой).

ЗЭЭ II харвуулын сумны зэвийн үүсгэрийг тоссон газар ба мөн үүсгэрийн завсарт хийх таван нүд цоолборлосон бяцхан булцуу, харвахад нүднүүдэд салхи тосч исгэрэн дуугарна; *сумны зээ.*

ЗЭЭ III төрсөн хүүхний буюу эгч, охин дүүгийн хүүхэд; **зээ ач** (охин дүүгийн хүүхэд).

ЗЭЭ IV: **зээ хас** хамгийн дээд зэргийн хас.

ЗЭЭГ I 1. зарим эдлэл юмны захаар нь тойруулан хадсан, оёсон дээс утас мэт юм; *дээврийн зээг; ширдгийн зээг;* 2. нарийн дээс; *зээг томох.*

ЗЭЭГ II хэш, зэл.

ЗЭЭГЛҮҮЛЭХ зээглэхийн үйлдүүлэх хэв.

ЗЭЭГЛЭХ I юманд зээг барьж оёх.

ЗЭЭГЛЭХ II жигдрэн зэрэгцэх; *зээглэж зогсох; зээглэж хоргоох.*

ЗЭЭЛ I 1. хот тосгоны гол гудамж; **гудамж зээл** х о р ш.; 2. худалдааны бөөгнөрсөн газар; *зах зээл; худалдаа зээл.*

ЗЭЭЛ II өр, ор төлөөс үнэ өртгийг өгөөгүй авсан юм; *зээл авах; зээл өгөх; өр зээл; мөнгө зээл авах; худалдааны зээл авах; удаан жугацааны зээл авах; зээлээр худалдаалах; зээл тавих.*

ЗЭЭЛДҮҮЛЭХ зээлдэхийн үйлдүүлэх хэв.

ЗЭЭЛДЭГЧ зээл авагч этгээд; *мөнгө зээлдэгч; бараа зээлдэгч;* **нэр зээлдэгч**; (бусдын нэрийг төлөөлөгч).

ЗЭЭЛДЭХ 1. зээлэх, зээлд өгөх; 2. нэр зээлэх; **тоо зээлдэх** (хасах тооны үйлдэлд хасагч нь хасагдагчаас их байвал өмнөх оронгоос бүтэн аравтыг зээлэн авах); **зээлдэн туслах касс** (түр хугацаагаар мөнгө зээлдүүлэх олон нийтийн байгууллага).

ЗЭЭЛЛЭГ тодорхой нөхцөлд түлгуурлан мөнгө зээл авах санхүүгийн арга явууллага; *зээллэг авах; зээллэг өгөх; хонжворт зээллэг.*

ЗЭЭЛҮҮЛЭХ зээлэхийн үйлдүүлэх хэв.

ЗЭЭЛЛЭГЭЭ зээлэх нь; *зээллэг гаргах; зээллэг захиалах; улсын хонжворт зээллэгээ.*

ЗЭЭЛЭХ 1. бусдын юмыг хожим төлөхөөр авах; *мөнгө зээлэх;* 2. бусдын нэр барих; *нэр зээлэх.*

ЗЭЭНЦЭР зээгээс төрсөн хүүхэд.

ЗЭЭР а м ь т а н хос туурайтны хэсэг, хивдэг гөрөөс, саруул тал газар сүрэглэн явна, төрөл зүйл олон, авлаж мах арьсы нь ашиглана; *цагаан зээр; сүүлт зээр;* **зээрэн бут** у р г а м а л (сороолийн нам, хээр хөдөө ургана, цогц 30 см. орчим, зуны эхэн хувьд ногоон найлзуур ба жижиг хармаг үр гарна); **зээрэн төлөг** у р г а м а л (өндөр нь 50—60 см. бамбай хэлбэртэй цагаан цэцэгтэй, олон наст ургамал, ногоон байхад нь үхэр идэх дуртай); **зээрэн дэл** у р г а м а л (багалуурын нэг төрлийн ургамал); **зээрэн шилбэ** у р г а м а л (иш шулуун, мөчир олон, цэцгийн өнгө нь ягаавтар цагаан нэг зүйл олон наст ургамал, ногоон байхад нь тэмээ идэх дуртай); **зээрийн унд** у р г а м а л (сайр урсгал газарт бутлаж ургана, өндөр нь 30 см. орчим ишний бүдүүн 3 мм. хүртэл, түрүү яармын адил, үндэс нь услаг нэгэн зүйл ургамал).

ЗЭЭРГЭНЭ у р г а м а л ихэвчлэн уул тал газар ургана, өндөр нь 30 см. орчим, үндэс хол, навч цэцэггүй, дэрсний хир бүдүүн, шилмүүсний дүртэй бөгөөд ганд тэсвэрлэх нь сайн, дөрвөн цагт ногоон.

ЗЭЭРД адууны нэг зүйлийн зүсэм, **өнгө** улаан бөгөөд холоос үзэхэд бараан мэт харагдана; *хүрэн зээрд; хуа зээрд;* **улаан зээрд** (а. улаан өнгө орсон морины зүс; б. архинд ихэд халамцсан нь; *архи ууж улаан зээрд болсон хүн явж байна);*

ЗЭЭРДЭГЧ зээрд зүстэй охин адуу; *зээрдэгч гүү; зээрдэгч байтас.*

ЗЭЭРЭНХИЙ хавтгай бөгөөд дугуй хэлбэртэй юм; *биеийн тамирын зээрэнхий.*

ЗЭЭТҮҮ нэг талдаа үзүүртэй, нөгөө талдаа онгитой, ишлэж газар эрэх малтах зэвсэг.

ЗЭЭТҮҮДҮҮЛЭХ зээтүүдэхийн үйлдүүлэх хэв.

ЗЭЭТҮҮДЭХ зээтүүгээр цохих, дэлдэх.

ЗЭЭХ а м ь т а н суусрын нам, хөхөөр өсөх араатан амьтан, үс сахлаг, өнгө хар бор, магнай ба чихэндээ цайвар толботой, хажуу дагуу цайвар зурвастай; *зээх малгай; зээхийн арьс үнэтэй.*

И

И монголын цагаан толгойн үсэг, И авиа, И эгшиг.

ИВ I хүч нэмэгдүүлэх үг; *ив ил; ив илэрхий; ив илхэн; чиний бодол ив илэрхий байна.*

ИВ II 1. цоо, цөм, нэвт; *ив цохих; ив дайрах;* 2. нүр, пин; *ив хийх; тэнгэр ив хийтэл сүрхий дуугарав.*

ИВ III таг, огт; **ив чив** х о р ш . .

ИВЛҮҮЛЭХ I ивлэх I-ийн үйлдүүлэх хэв, ивлэгэх; *үнээгээ ивлүүлэх.*

ИВЛҮҮЛЭХ II ивлэх II-ын үйлдүүлэх хэв, ивлэхэд хүргүүлэх.

ИВЛЭГЭХ ивлэхэд хүргүүлэх, ивлүүлэх; *үнээгээ ивлэгэн зогсов.*

ИВЛЭХ I 1. амьтны сүү, хөхөндөө бууж ирэх; *үнээ ивлэх;* 2. бяцхан усны сэггүй ундрах; *горхи ивлэх.*

ИВЛЭХ II цөмлөх, цоо татах, иврүүлэх; *дээлийнхээ хормойг ивлэчихэв.*

ИВРҮҮЛЭХ иврэхийн үйлдүүлэх хэв, иврэхэд хүргүүлэх.

ИВРЭХ юмны цоо үсрэх, цөм үсрэх, язрах; *сүхээр цохиход банзан туурга иврэн унажээ; газар иврэх.*

ИВТНЭХ 1. жижиг амьтны явах, хөдлөх; *хорхой ивтнэх;* 2. хүний бие гүвэгнэн загатнах мэт болох; *бие ивтнэх.*

ИВҮҮЛЭХ ивэхийн үйлдүүлэх хэв, ивэхэд хүргүүлэх.

ИВҮҮР 1. ивээс, ивэх юм; *авдарны ивүүр; шалны ивүүр;* 2. бусдын ая байдалд нийцүүлэхэд чадамгай хүн; *ивүүр хүн;* 3. юм хум байсаар байтал ямагт байхгүй гэж царай алдаж байдаг заншилтай хүн; *хэтэрхий ивүүр амьтан.*

ИВЭР: ивэр шивэр нуущгайгаар шивнэн хэлэлцэх; *ивэр шивэр ярих;* **ивэр зэвэр, ивэр авир** х о р ш . .

ИВЭРХИЙ 1. юмны ивэрсэн газар; ***хөхүүрийн ивэрхий; ивэрхий ёроолтой;*** 2. **нарийн** гэдэс мэтийн дотоод эрхтэн хэвлийн **хөндий**гөөс унаж арьсны дор гарч ирэх; *цавины ивэрхий; ивэрхий хүн.*

ИВЭХ 1. юмны дор юм тавьж өндөрлөх, хөндийлөх; *авдар дор мод ивж тэгшлэх;* 2. пай

наадахад ямар модыг хаана өрж хураасныг тэмдэглэн мэдэх; *чи битгий мод ивээд бай;* 3. ш и л ж с э н нийлэмжтэй ааш зан гаргах; *ивж гарч байна;* 4. юмтай мөртөө юу ч үгүй гэж царай алдах; *ивүүр хүн ивж л байгаа биз.*

ИВЭЭГЧ ивээх зантай, өршөөх хайрлах сэтгэлтэй.

ИВЭЭЛ 1. ач тус, тэтгэмж хамгаалал; *таны ивээлээр бид сайн явж ирэв; ээлт морь, ивээлт ээзэн* ш ү л э г; 2. харш биш, нийлэмжтэй зохимжтой байдал; *ивээл сайтай; ивээл муутай.*

ИВЭЭЛГҮЙ харш, нийлэмж зохимжгүй, өршөөлгүй; *ивээлгүй хүн гэнэ билээ.*

ИВЭЭЛТЭЙ харшгүй, нийлэмжтэй, зохимжтой, өршөөлтэй; *ивээлтэй сайн хүн байв.*

ИВЭЭЛГЭХ ивээхийн үйлдүүлэх хэв, ивээхэд хүргүүлэх.

ИВЭЭС юмны дор ивэх юм; *авдарны ивээс; орны ивээс.*

ИВЭЭХ энэрэх, өршөөх, тэтгэх, хамгаалах; *ивээж өршөөх; хайрлаж ивээх; түүнийг тэр гуай ивээх байлгүй дээ.*

ИГ I утас ээрэх гар ээрүүл; **игийн дугуй** (ээрүүлийн таваг); **игийн иш** (ээрүүлийн иш).

ИГ II: **иг маг хийх** (а. харилцан ялимгүй хэрэлдэх мэт үг өгүүлэл гаргацгаах: *та нар дандаа иг маг хийлцэж байж яахин болох вэ;* б. шуурхай хөдөлгөөнтэй бишбайдал гаргах; *иг маг хийсний хэрэггүй, элбэж хамжаад бушуухан хийцгээе;* в. эрс шийдвэргүй; *иг маг хийсэн хачин хүн.*

ИГДҮҮЛЭХ игдэхийн үйлдүүлэх хэв, утас ээрүүлэх.

ИГДЭХ игээр утас ээрэх.

ИГЭРГЭХ I ий ий гэж бархирч эхэр татан ихэд уйлах; *битгий игэргээд бай!*

ИГЭРГЭХ II 1. хүний эв хав муутайгаар ярих; 2. чичирхийлэх, давжганах.

ИГЭРГЭХ III морь мал унаж ергүүлэн явах; *игэргэсээр явж ирэв.*

ИГЧ ургамлын нярт шигүү; *игч ургацтай газар.*

ИД I 1. гарамгай давуу чадал чадвар; *ид залуу насан дээрээ явааа хүн; идтэй эм; ид хүчтэй үедээ заан болсон юм,* **ид хав** х о р ш.; 2. эрч хүч ихтэй; *ид халуун; ид хүйтэн;* 3. эдлэх хэрэглэхэд таатай сайн; *идтэй багаж; идтэй морь;* 4. урагштай шуурхай яваа; *ажил ид дундаа оргилж байна; одоо ид ажилтай цаг.*

ИД II: **ид шид** шашны ёсны ер бусын чадал; *ид шид үзүүлэх; ид шидтэй.*

ИДГҮЙ 1. чанар чадалгүй, ид муутай; 2. их зальтай, мэхтэй; *тэр чинь идгүй заль мэхтэй хүн;* 3. маш дүрсгүй; *тун ч идгүй ааштай хүүхэд шүү.*

ИДЕАЛИЗМ оршин ахуй юмны эх үндэс бол материи биш оюун санаа гэж үздэг материализмын эсрэг философийн үрсгал; *субъектив идеализм.*

ИДЕАЛИСТ идеализмыг баримтлагч.

ИДЛЭГ а м ь т а н начны намын нэгэн зүйл шувуу, гэрийн тэжээвэр болгож, туулай зэргийг агнахад хэрэглэнэ.

ИДМЭРТЭХ идэгдэх, элэгдэх, гасрах, тамтрахад хүрэх; *дээл идмэртэх; дээс идмэртэх; арьс идмэртэх.*

ИДМЭРШИХ идмэртэх шинжтэй болох.

ИДРЭЭ у р г а м а л навч урт, үндэс цагаан, амт гашуун, түүхийгээр идэвч, борлуулж идэвч болно, чанар зохимж сайн, зэрлэг таримал хоёр зүйл бий.

ИДТЭЙ I чадалтай, хавтай, бахтай, чанартай, зоригтой; *идтэй халуун; идтэй морь; идтэй сайн зураач.*

ИДТЭЙ II шидтэй, ер бусын чадалтай; *идтэй шидтэй.*

ИДТЭН I хүч чадал ихтэй амьтан; **идтэн чадалтан** х о р ш . .

ИДТЭН II шидтэн; *идтэн шидтэн.*

ИДҮҮЛЭХ 1. идэхийн үйлдүүлэх хэв, идэхэд хүргүүлэх; 2. идэгдэх; *чонод идүүлсэн малын сэг;* 3. бийрт бэх шилэмдэх; *бийрээ идүүлэх;* 4. эзлүүлэх; тонуулах; *тэр жил манай хушуу цагаантанд идүүлсэн юм.*

ИДҮҮР нохой гахай тэргүүтэнд хоол өгөх сав; *нохойны идүүр.*

ИДҮҮШ 1. дурлаж идмээр юм; *энэ өдрийн хоол идүүш сайтай хоол байлаа; тараг бол идүүш сайтай зүйл мөн;* 2. идэш; тэнд малын идэш байна.

ИДҮҮШГҮЙ идэхийн аргагүй, идэхэд бэрхтэй.

ИДҮҮШТЭЙ идүүш бүхий; *идүүштэй билчээр; малын идүүштэй нутаг.*

ИДЭВХ мэриймж, чармайлт, санаачлага; мэрийлт; *идэвх гаргах; идэвх сайтай;* **идэвх зориг, идэвх хичээл, идэвх зүтгэл** х о р ш..

ИДЭВХГҮЙ мэрийлт чармайлтгүй, санаачлагагүй.

ИДЭВХЖИЛ идэвхжих үйлийн нэр; *үйлдвэрийн ажилчдын идэвхжил улам сайжирч байна.*

ИДЭВХЖИХ идэвхтэй болох, идэвх орох.

ИДЭВХЖҮҮЛЭХ идэвхжихийн үйлдүүлэх хэв, *идэвхжүүлсэн нүүрс.*

ИДЭВХИЙЛҮҮЛЭХ идэвхийлэхийн үйлдүүлэх хэв, идэвх гаргуулах.

ИДЭВХИЙЛЭЛ идэвхийлэх үйлийн нэр.

ИДЭВХИЙЛЭХ идэвхлэх, идэвх чармайлт гаргах; идэвхийлэн оролцох.

ИДЭВХЛЭХ үйл явдалд санаа тавин хичээх, чармайх; *идэвхлэн оролдох.*

ИДЭВХТЭЙ идэвх зүтгэл сайтай, чармайлттай, мэрийлттэй, оролдлоготой; *идэвхтэй ажилласны үр дүнд олсон амжилт; идэвхтэй ажиллагаа.*

ИДЭВХТЭН идэвх зүтгэл гаргагчид; *намын идэвхтэн; идэвхтний хурал.*

ИДЭВХШИХ идэвх орох, идэвх нь сайжрах.

ИДЭВХШҮҮЛЭХ идэвхшихийн үйлдүүлэх хэв, идэвхий нь сайжруулах.

ИДЭГДЭХ идэхийн үйлдэгдэх хэв, идэх үйлийг биедээ дааж авах; *усанд идэгдэх; дайсанд идэгдэх; ярд идэгдэх.*

ИДЭМГИЙ их иддэг идэмхий.

ИДЭМХИЙ 1. идэхэд ховдог амьтан; *идэмхий үхэр; идэмхий хүн;* 2. ш и л ж с э н хээл хахуульд дуртай; *идэмхий түшмэл.*

ИДЭМШ өвс билчээр ховор газарт энд тэнд нуугдмал байгаа бага сага өвс, идүүш ч гэнэ; *малаа идэмш дагаж билчээрлүүл!*

ИДЭНГЭ идэхэд таатай, аятай юм; *идэнгэ сайтай; идэнгэ муутай;* идэнгээр ч гэдэг.

ИДЭНГЭРТЭХ идэнгэ байдалтай болох.

ИДЭНГЭШИХ идэнгэ шинж байдал орох.

ИДЭР залуу; **идэр залуу** х о р ш.; *идэр нас; идэр чийраг хүн.*

ИДЭРЖИХ идэр болох.

ИДЭРЛЭХ идэр байдал гарах.

ИДЭРХЭГ эрэлхэг, хүчирхэг; *идэрхэг гүрэн; идэрхэг эр.*

ИДЭРХЭН идэр залуу; залуухан; *идэрхэн насандаа цэрэгт явж билээ.*

ИДЭРХЭХ 1. идэрхэг зан байдал гаргах; 2. хүчирхэх, дээрэлхэх, омгорхох.

ИДЭРШИХ идрийн шинжтэй болох.

ИДЭХ 1. амьтны юмыг хоол болгон хэрэглэх; идэшлэх; *алим идэх; мах идэх; талх идэх; чихэр боов идэх; өвс ногоо идэх; идэх юм;* **барьж идэх** (а. шүүрэн авч идчих; *ялаа барьж иддэг аалз; чоно барьж идэх;* б. загнаж аашлах, үлэмж хэрцгийлэх; *намайг загнаад барьж идэх шахав); идэхээс өөр идгүй з ү й р; олон нохой хүн идэх, олон хүн, хүн үл идэх з ү й р;* 2. хороож барагдуулах, сүйтгэх; *түймэр идэх; зэв идэх; яр идэх; өт идэх; хорхой идэх;* 3. эд юмыг ашиглан завших; *улсын эд хөрөнгийг хулгайн аргаар идэж ашиглах; мөнгө идсэн хүн; хээл хахууль идэх;* 4. тоглоход нөгөө эсэргүүцлийн хувиас дарж өөртөө авах; *даалуугаар идэх; бэрсээр идэх;* 5. эзлэх, тонох; *цагаантан, баатар бээлийн хүрээг идээд цааш хөдлөв.*

ИДЭХЭЭР идэх юмыг зөвхөн хэрэглэхийн хирээр хэмжих нь; *зүни халуун цагт махыг идэх идэхээр авсан нь дээр байдаг.*

ИДЭШ 1. идэх юм; *идэш хоол; махан идэш; идэш уушны дэлгүүр;* 2. өвөл хаврын улиралд хэрэглэх мах; *өвлийн идэш;* **идэш хийх, идэш гаргах** (өвөл хаврын идэх хоолонд мал нядалж бэлтгэн авах); **идэш идэх** (а. идэш хийх; б. буудаас хээл хахууль авах, хяхаж мөлжих; в. тоглоход эсэргүүцлийн хувиас дарж авах); **идэш авах** (а. идэш хийх; б. хоол идэх); **идэш өгөх** (а. хахууль өгөх; б. тоглоход зориуд идэш бөлгох): 3. ш и л ж с э н хахууль болгож буюу хяхан мөлжиж авсан эд уурс; *хахууль идэш; хяхмал идэш;* 4. ш и л ж с э н багажны даац, даах чадал; *идэш ихтэй хуурай; идэш сайтай хөрөө;* 5. тоглоход эсэргүүцлийн хувиас дарж авах юм; *идэш өгөх; хэрэгцээ тохиолдвол хэдэн идэш ч өгөхөд зүгээр;* 6. буунд орох сум дарины хэм; *нэг идэш дарь; идэш багатай буу.*

ИДЭШЛЭХ юм идэх; *мал билчээртээ идшилж байна; морио идэшлүүл.*

ИДЭЭ I 1. идэх юм; **идээ хоол, идээ цагаа** х о р ш.; **идээ боловсруулах самшуу** (ходоод);

цагаан идээ (малын сүү шимээр боловсруулсан идээний зүйл); 2. монгол айл, зочин хүнийг ирэхэд тавьж өгч амсуулах зүйл: *таваг-тай идээнээс амсах; цай идээ өгсний дараа асуусан нь...;* **идээ боов** х о р ш.; 3. үр жимсний доторхи зүйл; хатуу бүрхэвчтэй үр; *самрын идээ; хушганы идээ; чавганы идээ;* 4. цай чанахад хийх хуурай цай; *идээ нь ихдэх; идээ орох; цайны идээ;* 5. гурилаар хучиж хийсэн хоолны дотор хийх холио; *мантууны идээ; буузны идээ;* **идээ тавих** (а. цагаан идээний зүйлийг хатаахаар сав дэлгэц дээр тавих: б. хүнийг зочлон цайлахад элдэв идээг тавиглан өгөх); **идээ байх** (идээ хоол зохихгүй, үл шингэн өвчин болох); **идээ бээх** (өмхийгөөр хэхрэх); **идээ сонгох** (жирэмсэн хүний элдэв юм идье гэж хүсэх).

ИДЭЭ II арьс ширний зүйлийг боловсруулах тусгай уусмал; *арьс идээлэх идээ; идээ сайн орсон арьс элдэхэд хялбар.*

ИДЭЭ III идээр, амьд бие махбодын ялзарснаас гарах муухай үнэртэй шингэн зүйл; **идээ бээр** х о р ш.; *ярны идээ; шархны идээ;* **идээ суух** (а. ургамлын зүйлд үр цөм бий болон боловсрох; *самрын борогцойд идээ суужээ; тарианд идээ суух байна;* б. идээлсэн арьс ширэнд идээ орж эхлэх; *нэхийд идээ суужээ;* в. яр түүхийд идээ татах); **идээ орох** (арьс ширд идээ суух); **идээ татах** (а. яр түүхий дотор бээр хуралдах; б. арьс шир зэрэгт тараг аарц шүү зэргийг түрхэх); **идээ шахах** (яр түүхийн бээрийг шахаж гаргах).

ИДЭЭЛҮҮЛЭХ идээлэхийн үйлдүүлэх хэв, идээлэхэд хүргүүлэх.

ИДЭЭЛЭХ I идээ хоол идэх; *бид идээлээд гарав.*

ИДЭЭЛЭХ II тусгай найруулсан зүйлд юм дүрж, түрхэж боловсруулах; *арьс идээлэх; нэхий идээлэх.*

ИДЭЭЛЭХ III 1. идээ бий болох; *шарх идээлэх; идээ татах;* 2. идээмэртэх.

ИДЭЭМЭРТЭХ хавдсан газар баалж эхлэх.

ИДЭЭН хүний аливаа идэх юм.

ИДЭЭР яр шархны бээр идээ.

ИДЭЭРЛЭХ яр шарх баалж идээ татах.

ИДЭЭШИЛ идээших үйлийн нэр; *идээшил сайтай; идээшил муутай.*

ИДЭЭШИХ 1. юмны шим шүлт юманд бууж шингэх; *цай идээших; эм идээших;* 2. хүн амьтны харилцан дасах, зохицох, тохирох, ижилсэх, гаршиж дамших, *эрт урьдаас эхлэн миний идээшсэн нутаг; говьд идээшсэн мал, нэг хэсэгтээ хангайд идээшихгүй; би түүнд гаршиж идээшсэн юм.*

ИДЭЭШЛЭХ идээшил олох.

ИДЭЭШМЭЛ идээшсэн юм; *идээшмэл цай; идээшмэл нутаг.*

ИДЭЭШҮҮЛЭХ идээшихийн үйлдүүлэх хэв, идээшихэд хүргүүлэх.

ИЖ дутуугүй, бүрэн тэгс, гүйцэд юм; *Ленин-ий иж зохиол над бий; тасалгааны иж хэрэглэл;* **иж үг** (бяцхан ялихгүй үг); **ижтэй** (иж тохирсон).

ИЖИЙ эжий; *ижий минь миний төлөө сэтгэл зовох хэрэггүй.*

ИЖИЛ I маш адил; *ижил морь; ижил дээл; ижил ширээ; ижил өнгө; ижал хос; яг ижил; эгээ ижил; ив ижил.*

ИЖИЛ II амьтны харилцан дассан нь; *ижил дасал болох; хул морьтой зээрд морь ижил дасал болжээ; ижил буруу адуу явна.*

ИЖИЛГҮЙ I адилгүй, ижил биш; *миний хүрэн морь ижилгүй хурдан даа; таны ногоон соруул ижилгүй байх аа.*

ИЖИЛГҮЙ II 1. ханьгүй, хосгүй; *ижилгүй өнчирсөн амьтан; ижил ханьгүй ганцаардаж байна; ижлээ идэж, ханиа хаясан этгээд;* 2. гаргууд, онцгой; *эрдмээр ижилгүй хүн; ижилгүй муу ааштай амьтан.*

ИЖИЛДҮҮЛЭХ ижилдэхийн үйлдүүлэх хэв, ижил болгох.

ИЖИЛДЭХ ижилсэх.

ИЖИЛСГЭХ ижилсүүлэх, ижил болгох, адил болгох.

ИЖИЛСҮҮЛЭХ ижилсэхийн үйлдүүлэх хэв.

ИЖИЛСЭГ 1. амьтны ижлээ санан мөрөөдөх зантай; 2. амьтны маш гүргэн ижилсэх нь.

ИЖИЛСЭХ 1. харилцан адил ижил болох; 2. харилцан дасч ээнэгших.

ИЖИЛТГЭХ ижилсгэх.

ИЖИЛТЭХ 1. ижилсэх; 2. ижилших.

ИЖИЛШИХ 1. ижилсэх шинжтэй болох; 2. ижил болох.

ИЖИЛШҮҮЛЭХ ижилшихийн үйлдүүлэх хэв.

ИЖИР: ижир нугас а м ь т а н шогшир нугастай адил бөгөөд маш жижиг нэгэн зүйл шувуу, махны амт маш сайн.

ИЗ а м ь т а н нэг төөгөөс уртгүй, далайгаас голын усанд шилждэг нэгэн зүйл загас.

ИЙ юмнаас айх айлгахад гаргах аялга; *ий тэр горьгүй шүү! ий би айж байна;* **ий ий** (*бага хүүхдийг айлгах аялга; ий ий хадны мангаа! ий ий аажуу!*).

ИЙГЛЭХ үхэр цууцалийн дуугарах.

ИЙГЭЭС 1. найдлага тавьснаа илэрхийлэхэд хэрэглэнэ; *ийгээс танил хүн гэсэндээ яах вэ, тус боллоо шүү; ийгээс тэхгүй байлгүй дээ;* 2. арай, дээнч; *ийгээс тийм хүн биш; ийгээс ийгэх чингэхгүй нь лав.*

ИЙЖ: ийж хийж арай чамай, дөнгөж дангаж; *ийж хийж шалгалтаа өгөв; ийж хийж амьдарч явна.*

ИЙЛЭХ: ойх ийлэх амьтны оргон зайлж энд тэнд шургалан явах.

ИЙМ чухамхүү нүдний өмнө, ойр байгаа юмыг заах ба үйл явдлыг тухайлан өгүүлэхэд хэрэглэх үг; *ийм сайхан өдөр! ийм байшинд сууж байна; ийм зантай хүн; ийм нэг хүн байв; учир нь ийм билээ...;* **ийм тийм** (хэд хэдэн үг юмыг хамтатган өгүүлэхэд хэрэглэнэ; *ийм тийм үг; ийм тийм юм);* **иймийн тул** (аливаа юмны учир зүйг бүрэн өгүүлээд түүнээ хураангуйлан хойт үгийг удирдахад хэрэглэх үг; *иймийн тул хичээлтэй байна; иймийн тул сурах хэрэгтэй*).

ИЙМХЭН чамлах санаа, баахан ийм; *ердөө иймхэн гэж үү? иймхэн хоолоор цадахгүй.*

ИЙМЭРХҮҮ энэ мэт; *иймэрхүү санаатай; ийм янзын; иймэрхүү төлөвтэй.*

ИЙМЭРХҮҮХЭН арай иймэрхүү, баахан иймэрхүү.

ИЙН: I ингэж, ийн хэмээн; **ийнхүү** (ийм, энэчлэн); **ийн тийн** (хааш яаш, ийм тийм, ингэж чингэж; *ийн тийн үг хэлэлцэх.*

ИЙН II ингэж, *ийн гэж; ийн тийн; ийнхүү; ийн гэвч.*

ИЙНХЭН хүнийг наашихнаа бол гэсэн үг, ийнээн ч гэдэг.

ИЙР: ийр чийр хийх ийр чийр гэж чахран дуугарах аялга.

ИЙШ энэ тийш; *ийш бол; ийш тийш явах; ийш суу! ийшээ оч!*

ИЙШДҮҮЛЭХ ийшдэхийн үйлдүүлэх хэв.

ИЙШДЭХ хэтэрхий ийш болох.

ИЙШЛҮҮЛЭХ ийшлэхийн үйлдүүлэх хэв.

ИЙШЛЭХ ийш болох; *би ийшлэх гээж байна, чи явах уу?*

ИЛ I далдтай эсэргүүцэлдсэн утга 1. далд биш, дотор биш; *хүнд харагдахуйц газар ил тавих; ил гаргах; ил задгай; ил захиа; далласан газар нь ил гарч, далайсан газар нь далд орох;* з ү й р; 2. нууц биш, илэрхий, тодорхой; *ил хэлэх; санал ил хураах; ил хэрэг; таны саная бодол тун ил байна.*

ИЛ II бугын зулзага, илий ч гэнэ.

ИЛБҮҮР бусдыг мэхлэсхийн хуурдаг зан.

ИЛБҮҮРДЭХ илбүүр зан байдал гаргах.

ИЛБҮҮРХЭН нилээд илбүүр зантай.

ИЛБҮҮРЧ илбэрч бусдыг мэхлэсхийн хуурах зантай хүн.

ИЛБЭ ховс; *илбэ үзүүлэх; илбэ гаргах.*

ИЛБЭГНЭХ ялбаганах.

ИЛБЭДҮҮЛЭХ 1. илбэдэхийн үйлдүүлэх хэв; 2. илбэдэгдэх.

ИЛБЭДЭГДЭХ илбэдэхийн үйлдэгдэх хэв, илбэдүүлэх.

ИЛБЭДЭХ илбэ үзэгдэл гаргах.

ИЛБЭЛЗЭХ ялбалзах.

ИЛБЭНХ элбэнх.

ИЛБЭРҮҮ таатай, ялгум, аятай; *илбэрүү зантай хүн; илбэрүү тааламжтай эд.*

ИЛБЭРҮҮХЭН баахан илбэрүү.

ИЛБЭРЭХ юмны тааламжтай зэ дагуу болох.

ИЛБЭС: илбэс дэлбэс хийх 1. мал гөрөөсний юмнаас гэнэт гэнэт сочмог зайлах; 2. худалч хүний итгэшгүй байдал гаргах.

ИЛБЭСХИЙХ морь малын сочиж гэнэт зайлах.

ИЛБЭХ 1. гараар зөөлөн арчих; *нүүрээ илбэх;* 2. өршөөн тэтгэж хүмүүжүүлэх; *илбэн тохинуулах; илбэн өршөөх; илбэж тэжээх.*

ИЛБЭЧ илбэ ховстой хүн.

ИЛБЭЭР юмны үс ширхгийн налуу дагуу; *илбээр үстэй дээл.*

ИЛБЭЭС 1. загас барихад хэрэглэх өгьөө; хавх зүүхэд сүргийг торгох тэвх.

ИЛБЭЭСДЭХ загасыг илбээсээр барьж агнах.

ИЛБЭЭСЛЭХ хавхны сүргийг илбээсээр тэвхдэн торгож тогтоох.

ИЛГЭДҮҮЛЭХ илгэдэхийн үйлдүүлэх хэв.

ИЛГЭДЭХ 1. юманд илгэ наах; 2. үнэт арьсны энг арвитгах буюу үсийг тархай болгохын тул хөрсийг хагалж завсраар нь нарийн илэг барьж оёх; *булга илгэдэх.*

ИЛГЭЭЛГЭХ илгээхийн үйлдүүлэх хэв.

ИЛГЭЭЛТ илгээсэн хүн юм, явуулсан зүйл; төв хорооны илгээлтээр залуучуудыг атар газар явуулах; илгээлтээр хөдөө ажиллах; *шуудангийн илгээлт; шуудангийн илгээлтийн тасаг.*

ИЛГЭЭХ явуулах, хүргүүлэх; *хүн илгээх; бичиг захидал илгээх; илгээх бичиг.*

ИЛД I хуйд дүрж зүүх сэлмээс арай бага хутга; **дам илд** (том илд).

ИЛД II үлд.

ИЛД III: **илд өвс** у р г а м а л уул хярд ургана, навчны дүр самрын боргоцойтой адилшиг бөгөөд өнгө улаавтар хуа, язгуур ба ишийг бүрхэн ургадаг ургамал.

ИЛДЭН: илдэн арт а м ь т а н ардаа цагаан чандар бүхий бүдний нэг төрлийн шувуу.

ИЛДЭХ далдалбал зохих юм ил болох, хэтэрхий ил болох.

ИЛЖИГ (ИЛЖГЭН) амьтан морьтой адилшиг болоод бие жижиг, чих том, үхэр шиг сүүлтэй нэгэн зүйл адуу; **илжгэн хулгана** (туурайт хулгана); **илжгэн чих** у р г а м а л (модонд ургадаг, хэлбэр бөөрөнхийвтэр өнгө шар амт амтайхан жимс, зүйл олон): **илжгэн чихэн цэцэг** у р г а м а л (модорхог иштэй, илжигний чихтэй адил болоод шаравтар навчтай, сондуутай цагаан цэцэгтэй, өвөл цэцэглэдэг, гандаж шарладаггүй).

ИЛЖИМЧ а м ь т а н янз байдал нь самжийн адил болоод илжигний хиртэй, том, модонд асах авирахдаа маш чадамгай нэгэн зүйл гөрөөс.

ИЛЖИРХИЙ ялзарсан, ялзархай; *илжирхий нэхий.*

ИЛЖЛЭХ илжрэхэд хүргүүлэх.

ИЛЖРҮҮЛЭХ илжрэхийн үйлдүүлэх хэв.

ИЛЖРЭХ юмны гутаж ялзран тамтрах, ялзрах; *арьс илжрэх; илжирсэн нэхий.*

ИЛЛЭХ байн байн илэх, илчих.

ИЛРҮҮЛЭГЧ ил болгогч.

ИЛРҮҮЛЭХ илрэхийн үйлдүүлэх хэв, ил болгох; *нууцыг илрүүлэх; хэрэг илрүүлэх.*

ИЛРЭЛ илрэх үйлийн нэр; *үнэ бол өртгийн мөнгөн илрэл мөн.*

ИЛРЭХ илэрхий болох, ил гаргах; *хэрэг нь илрэх; хулгай нь илрэв.*

ИЛТ илэрхий, тодорхой, баримттай; **илт үнэн** (а. магад үнэн; б. нийгэм даяар хүлээн зөвшөөрсөн зөв зүй; в. өөрчлөн хувьсахгүй юм; г. тооны ухаанд тэнсэн магадлах шаардлагагүй маш илэрхий тоо, нийлэгдэхүүн байрыг соливч нийлсэн дүн нь хувьсахгүй тийм тоо); ☆ **илт хулгай** (зэвсэгт дээрэмчин).

ИЛТГҮҮЛЭХ илтгэхийн үйлдүүлэх хэв, илтгэхэд хүргүүлэх.

ИЛТГЭГЧ илтгэх үүрэг бүхий этгээд; *уран илтгэгч.*

ИЛТГЭЛ ямар нэгэн сэдвийг дэлгэрэнгүй тодорхойлсон нийтэд сонсгох, олны өмнө илтгэх зүйл; *илтгэл хийх; илтгэл айлтгал; тайлан илтгэл; илтгэлийн сэдэв.*

ИЛТГЭЛЧ илтгэдэг хүн.

ИЛТГЭХ 1. юмыг **ил** тодорхой болгох, илтгэл хийх; *илтгэгчээс илтгэхдээ хэлсэн нь;* 2. дээд удирдах хүмүүст албан хэргийн талаар мэдэгдэх, сонсгох; *сайдад илтгэх хэрэг;* **илтгэх хуудас** (албан хэргийг дээд газарт илтгэх бичиг).

ИЛТЭД ив ил, үзсээр харсаар; *илтэд мэдэгч; илтэд үзэгч.*

ИЛТЭХ юмны улмаар ил болох.

ИЛҮҮ 1. юмны тоо хэмжээ хэвээс хэтрүү; **илүү дэлүү** х о р ш.; *уртаараа илүү гарах; нэг банз илүү байна; илүү цагийн ажил; илүү хуруу* 2. сайн, давуу нэмүү; **илүү халиу** х о р ш.; *энэ хоёрын нэг нь чанараар илүү;* **илүү харах** (ахих, нэмүүд санаархах); **илүү гарах** (юмны зохих хэм хэмжээ нь хэвээс буюу эсэргүүцлээс давах); **илүү зан** (хэмээс хэтрүү зан, саваагүй зан; *илүү зан гаргах);* **илүү үг** (хэмээс хэтрүү үг, чалчаа үг; *илүү үг хэлэх*); **илүү орон тоо** (а. тогтоосон орон тооноос хэтрүү; б. хэрэгцээ багатай орон тоо); **илүү үзэх** (а. сайн харах; б. өөрөөсөө давууд атаархах); **илүү дорыг тэмцэх** (ямар нэгэн юмны дээр дор, илүү дутууг тэнсэлдэх, харилцан булаалдах); **илүү дэлүүгүй, илүү дутуугүй** (яв цав тохирсон буюу ав адил юм; *илүү дэлүүгүй тохиров; илүү дэлүүгүй яг адил);* **илүү гэр** (юм

агуулах, мал оруулах зэрэг аахар саахар зүйлд хэрэглэх гэр); **илүү од** з у р х а й (сарны зурхайн ёсны арван нэгэн гаргийн нэг бөгөөд хорин өдөр нэгэн хэмжээ, хорин есөн жилд нэгэн эргэлт болно); **илүү сар** (сарны зурхайн ёсонд гурван жилд нэг удаа тохиолддог илүү гучин хоног; *зуны илүү дунд сар).*

ИЛҮҮВТЭР баахан илүү, арай илүү.

ИЛҮҮДҮҮЛЭХ илүүдэхийн үйлдүүлэх хэв.

ИЛҮҮДЭЛ илүү гарсан үлдэл юм; *илүүдэл мөнгө; хоолны илүүдэл; орон тооны илүүдэл.*

ИЛҮҮДЭХ илүү гарах, хэтэрхий илүү болох; *нэг төгрөг илүүдэж байна; хүн илүүдэхгүй, нэмэр л болно; тоолсон малаас чинь гурав илүүдээд байна.*

ИЛҮҮР 1. халааж юм хумыг наах унагаах, толируулахад хэрэглэх хэрэгсэл; *илүүр хайруул харуул гурав* (хэл зүгшрүүлэх үг); 2. шаврыг илж түрхэхэд хэрэглэх зэвсэг; *шаврын илүүр.*

ИЛҮҮРДҮҮЛЭХ илүүрдэхийн үйлдүүлэх хэв.

ИЛҮҮРДЭХ 1. халаасан илүүрээр дарж илэх; *илүүрдэн нугалаасы нь гаргах;* 2. шаврын илүүрээр ажиллах; *шаврыг сэвгүй болтол нь илүүрдэх хэрэгтэй.*

ИЛҮҮРЧ илүүрдэх үүрэг гүйцэтгэгч этгээд.

ИЛҮҮТГЭХ илүү болгох.

ИЛҮҮТЭХ улмаар илүү болох.

ИЛҮҮХЭН баахан илүү.

ИЛҮҮЦ 1. үлдэлтэй, элбэг, илүү болсон юм; *илүүц үг; илүүц хэрэг; илүүц эд;* 2. сур шагаа харвахад зөвхөн нэгэн өрөг харваж нөгөө этгээдээс татан хожсон сур шагаа; *илүүц харвах.*

ИЛҮҮЧ илүү үзэгч харагч этгээд; *илүүч хүн. илүүч зантай.*

ИЛҮҮЧЛҮҮЛЭХ илүүчлэхийн үйлдүүлэх хэв. илүүчлэхэд хүрүүлэх.

ИЛҮҮЧЛЭХ илүү гаргаж ашиглах; *илүүчилж авах; илүүчилж өгөх.*

ИЛХЭН улам тодорхой юм; *илхэн үзэгдэх уул; илхэн мэдэгдэж байгаа хэрэг.*

ИЛЧ (ИН) юмны халуун бүлээний хувь чанар; *нарны илч; галын илч; биеийн илч.*

ИЛЧИТ илч бүхий юм; *илчит үс; илчит нарны дор;* **илчит тэрэг** (дотоод шатлагаар хөдлөх галт тэрэг).

ИЛЧИХ байн байн илэх.

ИЛЧЛЭХ илэрхий биш байсан зүйлийг ил болгон гаргах; *хэргээ илчлэх; гэмээ илчлэх; биеэ илчлэх.*

ИЛЧҮҮ: илчүү мод у р г а м а л халуун оронд ургадаг мөнх ногоон мод, холтсоор нь лонх савны бөглөө хийнэ.

ИЛЭГ (ИЛГЭН) мал гөрөөсний элдсэн үсгүй арьс; *хонины илэг; зээрний илэг; бугын илэг; илгэн дээл; илгэн гутал; илгэн бээлий;* **хамба илэг** (нарийлан боловсруулж элдээд тусгай хээ гаргаж дармалласан илэг).

ИЛЭН: илэн далангуй учир явдлаа нууж хаалгүй илчлэх нь; *илэн далангүй ярилцах.*

ИЛЭРХИЙ 1. тодорхой, илтэд; *илэрхий харагдаж байгаа шалтгаан; өнөөдөр ирэхгүй нь илэрхий;* ☆ **илэрхий хулгай** (дээрэм); 2. нүүрэмгий, айж ичихийг мэдэхгүй.

ИЛЭРХИЙГЭЭР үзтэл ил юм.

ИЛЭРХИЙЛЭЛ 1. албан үйлдвэрийн газар, байгууллагын нэр буюу үйл ажиллагааг бичиж өлгөх самбар, хаяг; *сум хийдийн илэрхийлэл; хаалга дээрээ илэрхийлэлтэй хашаа;* 2. илэрхийлэлт.

ИЛЭРХИЙЛҮҮЛЭХ илэрхийлэхийн үйлдүүлэх хэв.

ИЛЭРХИЙЛЭЛТ илэрхийлсэн нь; *баярын илэрхийлэлт; сэхээтэн нарын илэрхийлэлт; илэрхийлэлт гаргах.*

ИЛЭРХИЙЛЭХ 1. юмыг илэрхий болгох, тоочих, тодорхойлох; *учраа илэрхийлэх; санаагаа илэрхийлэх; нийтэд илэрхийлэх;* 2. батлах, батлах бичиг; *хувьсгалт залуучуудын эвлэлийн гишүүний бат илэрхийлэх.*

ИЛЭХ I 1. гарын алгаар хөнгөн дайран өнгөрүүлэх, гараар таалах; *илэх таалах;* **толгойгий нь илэх** (өөгшүүлэх); 2. засах эмчлэх зорилгоор барилах, дарах, илэх; *нүүрийг илэх; илж засах;* 3. илүүрээр илүүрдэх; 4. юмыг өнгөнцөр нимгэн түрхэх; *шавар илэх.*

ИЛЭХ II явуулах, одуулах.

ИЛЭЭС илсэн нь; *шаврын илээс сайн болжээ.*

ИМ I хүн амьтны төмс, засаа; ☆ **им унжих** (ивэрхий өвчин).

ИМ II малын чихийг хагалж огтлон тэмдэглэсэн тэмдэг; *онь им; цуулбар им; «Оргил» нэгдлийн им; ухам им;* **им тэмдэг** х о р ш..

ИМАН: иман бор у р г а м а л хар дурстай, дүгрэгхэн навчтай, улаан хүрэн өнгөтэй, артай нэгэн зүйл мод.

ИМЖ а м ь т а н сүүгээр бойжигч уутат гөрөөс, урьд хөл богино, хойд хөл урт, сүүл бүдүүн бөгөөд хүчтэй, хойд хөл ба сүүлэнд тулгуурлан харайж явна.

ИМНҮҮЛЭХ имнэхийн үйлдүүлэх хэв.

ИМНЭХ I малыг агталж засах, хөнгөлөх.

ИМНЭХ II малын чихийг огтолж им тэмдэг тавих.

ИМНЭХ III ирмэх, нүдээр дохиолох.

ИМПЕРИАЛИЗМ капитализмын хамгийн эцсийн, хамгийн дээд шат; *империализм бол капитализмын дээд шат мөн.*

ИМПЕРИАЛИСТ дэвшилт үзэл санаа, ардчиллын дайсан том хөрөнгөтөн нар; *империалист гүрнүүд.*

ИМПОРТ гадаад гүрнээс ирүүлэх бараа юм.

ИМПОРТЛОХ гадаадаас импортын журмаар бараа юм ирүүлэх.

ИМРҮҮЛЭХ имрэхийн үйлдүүлэх хэв.

ИМРЭХ юмыг гарын эрхий долоовор хоёр хуруугаар хавчин эргүүлэх, турших; *утас имэрч нийтгэх; торгоны ясыг имэрч үзжээ; зузаан нимгэний нь имрэн үзэх.*

ИМСГЭЛ 1. харвуулын нэгэн суманд өдлөх гурван өдний нэг; *нэгэн имсгэл өд;* 2. санаа явдал харилцан нийцсэн; *нэг имсгэлтэй хүмүүс; нэг амьсгалтай ч гэдэг.*

ИМХЭРДҮҮЛЭХ имхэрдэхийн үйлдүүлэх хэв, эмхэрдүүлэх.

ИМХЭРДЭХ эмхэрдэх; *алчуур эмхэрдэх.*

ИМЧИХ байн байн имрэх.

ИМЧҮҮЛЭХ имчихийн үйлдүүлэх хэв.

ИМРЭС а м ь т а н янз үхэртэй адилхан, дөрвөн эвэртэй, сахлаг урт үстэй нэг зүйл амьтан.

ИМЭРСЭН 1. дарь үсэргэхийн зэрэгт гал асаах дарьтай хольсон холимог цаас даавуу; 2. бялт.

ИМЭЭ чимээ; **чимээ имээ** х о р ш.. .

ИН I амуу тариа амуушуулах (цайруулах), талхлах дугариг чулуу; *тарианы ин; ингийн тосгуур.*

ИН II **ин хорхой** өвчин үүсгэгч хорхой; *халдварт өвчний ин хорхой.*

ИН III ямар нэг зүйлийг хийх үйлдэх дур хорхойтой болох өвчин; *хулгайн ин.*

ИНАНГИ а м ь т а н давхтай адилхан толгойтой, биеийн байдал улаан, загас шиг сүүлтэй, далайд оршдог нэгэн зүйл загас.

ИНГҮҮЛЭХ I ингэх I-ийн үйлдүүлэх хэв.

ИНГҮҮЛЭХ II ингэх II-ын үйлдүүлэх хэв.

ИНГҮҮМЭЛ 1. найруулан талхалсан үнэрт хүжсийн зүйл; *ингүүмэл хүжис;* 2. талх хэмхдэг болгосон юм; *ингүүмэл будаа.*

ИНГҮҮХЭН: ингүүхэн үг энгийн хэлэлцэх үг. өгүүлэл.

ИНГЭМЭЛ тооны нэр, арван их тунамал, арван есөн оронтой тоо.

ИНГЭ таван наснаас дээших охин тэмээ; *ингэн тэмээ.*

ИНГЭХ I үйлийн төлөөний үг, чингэх, энэ мэтээр; **ингэх чингэх** х о р ш.; *би чамайг ингэхийг мэдсэнгүй; би ч бас ингэж гэж бодож байсан юм.*

ИНГЭХ II 1. юмыг талх хэмхдэг болгох; *хомоол ингэх;* 2. арьс бөс зэрэг юмыг нугалж зөөлрүүлэх; *арьс ингэх;* 3. амьтны нэгнээ хэмхэх нухах ба барилах нухлах зэргээр дорой буурай болгох үнгэх; *халтар нохой, хар нохойг ингэж гүйцлээ.*

ИНГЭЭД энэ янзаар, энэчлэн, энэ мэт; *ингээд цааш ажилмах хэрэгтэй; ингээд би яах вэ?*

ИНГЭЭН: ингээн үг газар газарт үрвэсхийн уламжлалцсан эзэнгүй үг.

ИНГЭЭХЭН ингээн.

ИНДЕКС заалт, хэлхээ; *нэрсийн индекс.*

ИНДИ нэгэн зүйл төмөрлөгийн нэр, өнгө цагаан, чанар зөөлөн давтагдана, хувилахуй ухааны язгуур махбод.

ИНДҮҮ халааж юмыг толируулан илүүрдэх зэвсэг; *цогийн индүү; цахилгаан индүү.*

ИНДҮҮДҮҮЛЭХ индүүдэхийн үйлдүүлэх хэв.

ИНДҮҮДЭХ индүүгээр илүүрдэх.

ИНДҮҮЛЭХ индэхийн үйлдүүлэх хэв; *тариа индүүлэх.*

ИНДЭР илтгэгчийн **өндөрлөг тай**; **илтгэгчийн** ширээ; *индэр .дээрээс үг хэлэх; сонин бичиг бол намын индэр мөн; индрийн хурал.*

ИНДЭХ ингээр тариа цайлгах талхлах.

ИНЖ I эцэг эх нь охиныгоо эрд өгөхөд дагуул болгон өгөх эд хөрөнгө; *инж мал; инж эд; инж дагуулах.*

ИНЖ II: **инж буурал** ургамал хоёр наст ургамал бөгөөд хөх цэцэгтэй, нэгдүгээр жилдээ үндэслэнэ, хоёрдугаар жилдээ цэцэглэнэ.

ИНЖЕНЕР техникийн дээд боловсролтой мэрэгжилтэн; *зам харилцааны инженер; цэргийн инженер.*

ИНСТИТУТ 1. дээд сургууль; 2. хүрээлэн;

ИНТЕРНАЦИОНАЛ 1. олон улсын нэгдэл; **эвхамтын интернационал** (дэлхий дахины эвхамт намуудын олон улсын нэгдэл); 2. эвхамт намын дуулал; *нийтийн интернационал; монгол интернационал* («Интернационал» гэдэг монгол дуу).

ИНТЕРНАЦИОНАЛИЗМ 1. бурзуйн засгийг түлхэн унагааж, бүх дэлхий дээр эвхамт ёсыг байгуулах тэмцэлд пролетарийн эв санааны нэгдэл; 2. бүх улс түмний эрх **чөлөө**, тэгш эрхийг хадгалан хамгаалах явдал ба үндэсний дээрэнгүй үзлийн эсрэг тэмцэх үзэл.

ИНТООР ургамал шид жимсний хир том, амт амтайхан, модонд **ургадаг** нэг зүйл жимс, улаан цагаан хоёр зүйл **бий**.

ИНТУРИСТ жуулчин.

ИНЧ I ин хөдөлгөгч хүн.

ИНЧ II 1. няс; 2. эрхий ядам **хоёр** хуруу агшин зуур хавирах хэм.

ИНЧДЭЛ инчдэхийн дуун гарах хэм, **ирмэ**лийн аравны нэг хувь.

ИНЧДЭХ 1. няслах, шавдах; 2. **эрхий** хурууны өндгийг мөн гарын бусад хурууны **өн**дөгтэй нийлүүлэн хавсарч хавиран дуугаргах.

ИНЧРЭЛТ хардай.

ИНЭЭГЧ инээдэг хүн; **инээгч уран** (хуурмаглан инээж мэхлэх зантай **хүн**).

ИНЭЭД инээх үйлийн нэр; **инээд сайтай** (инээхэд тэсвэртэй); **инээд муутай** (хэтэрхий инээдэг); *чамд инээд, над ханиад* зүйр; **инээд алдах** (инээд хүрч хориглон чадахгүй инээх); **инээд хүрэх** (инээд дэврэн хөдлөх): **хөх инээд нь хүрэх** (а. дургүй нь хүрч зэвүүцэн инээх; б. юмны мууд бах. тав нь ханаж инээх).

ИНЭЭДГҮЙ барагтай бол инээхийг мэддэггүй.

ИНЭЭДТЭЙ инээд ихтэй, инээд хүрэм, инээмээр; *инээдтэй явдал болов.*

ИНЭЭДЭМ 1. инээвэл буюу элэг доог хийвэл зохих зүйл бүхий юм; *инээдэм тоглоомын зүйл; инээдэм биш;* 2. инээд.

ИНЭЭДЭМТ инээдэм бүхий; *инээдэмт хэрэг явдал олон тохиолддог; инээдэмт хүн;* **инээдэмт жүжиг** (нийгмийн ба аж байдлын гэм бурууг шүүмжлэн шоолсон хошин сэдэвт жүжиг).

ИНЭЭДЭМТЭЙ өөрийн эрхгүй инээд хүрмээр байдалтай.

ИНЭЭЛГЭХ инээхийн үйлдүүлэх хэв, инээхэд хүргүүлэх; **инээлгэх хий** (итрогений исэл, өнгө үнэргүй, хүн байн байн амьсгавал инээдээ дарж чадахгүй болдог).

ИНЭЭМСЭГ инээсхийсэн байдал.

ИНЭЭМСЭГЛҮҮЛЭХ инээмсэглэхийн үйлдүүлэх хэв.

ИНЭЭМСЭГЛЭХ нүүр, ам, нүдэнд инээхэд ойрхон байгаа байдал илрэх; *инээмсэглэх царай гаргах.*

ИНЭЭСХИЙХ бяцхан инээмсэглэх.

ИНЭЭХ баясах, баярлах, хөөрөх санаа **таа**тай болох зэрэг сэтгэлийн хөдөлгөөнөөр амьсгалыг огцом огцом тасалдуулан тусгай нэгэн янзаар дуугарах; *чанга инээх; чимээгүй инээх; инээсэн хүнээс асуу, уйлсан хүнээс бүү асуу,* хууч

ИОД 1. хувилахуй ухааны язгуур махбод; 2. мөн махбодоор хийсэн эм.

ИПРИТ гичийн хий.

ИР I мэс зэвсгийн хурц этгээд; *сүхний ир; хөрөөний ир;* **ир тохируулах** (мэс зэвсэг **хурц**лах); **ир мохох** (а. ирт юмны ир элэгдэж муудах; б. амьтны идэрхэг байдал доройтох)

ИР II ид, чадал, зориг; **ир нэмэх** (зориг чадал нэмэх); **ир буурах** (доройтох); **хутганы ирэн дээр** (хамгийн эгзэгтэй үе дээрээ); **ир харих** (хүн амьтны хүчин тэнхлийн **хурц** чадамгайн хувь доройтож муудах).

ИР III дур, хүсэл; *ир нь ханах; ир ханахгүй;* **ир орох** (дур хүсэл орох): **ир дарах** (хорхойгоо дарах); **ир суух** (а. зориг чадал нэмэгдэх; б. ханалыг мэдэх болох).

ИР IV налдаа лагшим юм; *цавууны ир.*

ИР (ЭН) V тооны нэр, ная дээр арвыг нэмсэн нь; *есөн арав ер; ерэн төгрөг; ерэн нас наслах.*

ИРВЭГНҮҮЛЭХ ирвэгнэхийн үйлдүүлэх хэв, ирвэгнэхэд хүргүүлэх.

ИРВЭГНҮҮР ирвэгнэх нь; *ирвэгнүүр өвчин.*

ИРВЭГНЭХ 1. сэрвэгнэх, жирэлзэн хөдлөх, жирс жирс хийх, ирвэг ирвэг хийх; *хөл чилж ирвэгнэж байна; гар бадайран ирвэгнэх; 2.* зэрэглээнд холхи газрын байдал жирвэлзэн хөдлөх; *ирвэгнэн харагдах.*

ИРВЭЛЗЭХ байн байн ирвэс ирвэс хийх.

ИРВЭС амьтан мигуйн нам, барстай адилхан бөгөөд бие бага, дүгрэг бидэртэй, хөхөн тэжээлт араатан; *ирвэсийн арьс.*

ИРВЭСХИЙХ түр зуур ирвэлзэх.

ИРГҮЙ I ир байхгүй буюу мохоо, ир муутай; *иргүй хутга; иргүй хянгар.*

ИРГҮЙ II ид хав муутай, чадал зориг муутай; *иргүй амьтан.*

ИРГҮЙ III ханахыг мэдэхгүй, хорхой ихтэй, ховдог хомхой; *иргүй хүүхэд; иргүй гөлөг; ир нь ханахаа больсон хүн.*

ИРГҮҮЛ юмны гэдэргэн нугалсан өнцөг мөр; *ширээний иргүүл; авдарны иргүүл; ааварны иргүүл;* **иргүүлт ваар** (байшингийн саравчны захаар хөмөргөн дарах иргүүл гаргасан ваар.

ИРГҮҮЛГҮЙ иргүүл мөргүй юм.

ИРГҮҮЛТЭЙ иргүүл бүхий юм; *иргүүлт ваар; иргүүлт таваг.*

ИРГЭН 1. тухайн улсын байнгын хүн амын тоонд багтах бөгөөд үндсэн хуулиар олгосон бүх эрхийг эдлэх эрхтэй, үндсэн хуульд заасан бүх үүргийг биелүүлбэл зохих этгээд; *өөрийн улс орноо батлан хамгаалах явдал бол манай улсын иргэн бүхний эрхэм үүрэг мөн; Монгол Улсын иргэн;* 2. насанд хүрсэн хүн ард; **ард иргэн, хүн иргэн** х о р ш . ; 3. хүн ардтай харилцах хүндэтгэл; *иргэний эрх; иргэний зан суртлыг хүндэтгэх;* **иргэний хууль** (ард иргэдийн хоорондын эрх үүрэг, харьцаа, хариуцлага, учир холбогдлыг тодорхойлон, дагаж шийтгүүлэхээр тогтоосон хууль); **иргэний хэрэг** (эрүүгийн хуульд үл хамаарах, ард иргэний хоорондын харилцааны холбогдолтой хэрэг); **иргэний дайн** (улсын доторхи ангиудын зэвсэгт тэмцэл); **иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх газар** (иргэний гэрлэлт, салалт, өсөлт хоролт зэргийг бүртгэх байгууллага).

ИРГЭНШИЛ аливаа нэг нийгэмлэйин үеийн цэцэглэл, хөгжил.

ИРДҮГЭЭР дэс тооны ерд тохиолдсон нь; *ирдүгээр зүйл; ирдүгээрт заасан нь.*

ИРЖГЭР бэржгэр; *иржгэр даавуу; иржгэр судал.*

ИРЖИГНҮҮЛЭХ иржигнэхийн үйлдүүлэх хэв.

ИРЖИГНЭХ 1. иржгэр юмны иржиг иржиг хийх; 2.бяцхан юмсын үлэмж ихийн байдал.

ИРЖИЙЛГЭХ иржийхийн үйлдүүлэх хэв, иржийхэд хүргүүлэх.

ИРЖИЙХ иржгэр болох.

ИРЖИЛЗЭХ иржгэр юмны иржис иржис хийх.

ИРЖИХ ир суух, ханалыг мэдэх болох.

ИРЛҮҮЛЭХ ирлэхийн үйлдүүлэх хэв, ирлэхэд хүргүүлэх.

ИРЛЭХ юманд ир гаргах, юмны ирийг хурцлах; *сүх ирлэх; хөрөө ирлэх.*

ИРМҮҮДЭХ хэтэрхий ирмүүн болох.

ИРМҮҮЛЭХ I ирмүүн болгох, ирмүүн байдал гаргах.

ИРМҮҮЛЭХ II ирмэхийн үйлдүүлэх хэв, ирмэхэд хүргүүлэх.

ИРМҮҮН аагтай, чадалтай, дорвитой, сүрхий, хурц ширүүн, сайн; *ирмүүн ажиллаж байна; ирмүүн давхидаг морь; ирмүү даацтай багаж.*

ИРМҮҮСГЭХ ирмүүсэхийн үйлдүүлэх хэв.

ИРМҮҮСЭХ ирмүүн болох.

ИРМҮҮТГЭХ ирмүүтэхийн үйлдүүлэх хэв.

ИРМҮҮТЭХ улмаар ирмүүн болох.

ИРМЭГ юмны хоёр хавтгийн уулзар иртэй, хамартай газар; *ширээний ирмэг; эргийн ирмэг; уулын ирмэг; шоо дөрвөлжин юманд арван хоёр ирмэг бий.*

ИРМЭГДҮҮЛЭХ ирмэгдэхийн үйлдүүлэх хэв, ирмэглүүлэх.

ИРМЭГДЭХ ирмэгт тулах, тогтох, онох.

ИРМЭГЛҮҮЛЭХ ирмэглэхийн үйлдүүлэх хэв, ирмэг гаргуулах.

ИРМЭГЛЭХ 1. юманд ирмэг гаргах; *алчуур ирмэглэх;* 2. ирмэгийг дагаж явах; *уул ирмэглэх.*

ИРМЭГҮҮН ирмүүн.

ИРМЭЛ I цагийн хэм, хормын аравны нэг.

ИРМЭЛ II ирсэн юм; *ирмэл хүн; ирмэл хурга.*

ИРМЭЛХИЙЛЭХ 1. нүд байн байн анивалзах; 2. ирмэн дохиолох байдал гаргах.

ИРМЭХ нүд цавчисхийх; *нүд ирмэх зуур* (агшин зуур); *нүдээр ирмэн дохих.*

ИРТЭЙ I ир бүхий, мохоо биш, хурц.

ИРТЭЙ II ирмүүн, зоригтой.

ИРТЭЙ III хангалуун, сувдаг хомхой биш, ханалтай.

ИРТЭЛ хэтэрхий, дүүрэн чихчихсэн нь; *иртэл дүүрэв; иртэл цадав.*

ИРҮҮЛ I ирсэн юм, ирмэл юм; *ирүүл мал; ирүүл эд; ирүүл гөрөөс.*

ИРҮҮЛ II дуудах уриа; *ирүүл бүрээ; ирүүл харанга.*

ИРҮҮЛ III өрсөлдөгч этгээд.

ИРҮҮЛЭХ 1. ирэхийн үйлдүүлэх хэв, ирэхэд хүргүүлэх; *харцуу ирүүлэх; дуудаж ирүүлэх;* 2. өөртөө элсүүлэх, дагуулах.

ИРХЭРЭХ 1. нөр халдамгай байдал гаргах; *чи над ирхэрэхийн хүрэгүй, хувиа хичээж яв!* 2. архирах; *нохой ирхэрэх.*

ИРЧГЭР юмны ар ба өө бөхийн нягт шигүүгийн байдал; *булигаарын ирчгэр ар; ирчгэр хад чулуу.*

ИРЧИГНҮҮЛЭХ ирчигнэхийн үйлдүүлэх хэв.

ИРЧИГНЭХ ирчгэр юмны ирчиг ирчиг хийх.

ИРЧИЙХ ирчгэр болох.

ИРЧИЛЗЭХ ирчгэр юмны ирчис ирчис хийх.

ИРШИХ иржихийн шинж байдал орох.

ИРЭГ I нас гүйцсэн, агталсан эр хонь; *ирэ хонь; шар халзан ирэг.*

ИРЭГ II: **иргийн гэр** хуучирсан хаалганы хажуу дахь гэр, байшин.

ИРЭГЛЭХ хурга төлөг хуцыг хөнгөлөх.

ИРЭЛЦЭХ ирэхийн хамтран үйлдэлцэх хэв; *чи түүнтэй хамт ирэлцээрэй.*

ИРЭХ I одох явахын эсрэг утга; 1. аливаа юм тэндээс энд болох, ямар нэг юманд хүрэх, холоос ойр болох; *гэртээ ирэх; машинаар ирэх; зочин ирэх; захиа ирэх; бичиг ирэх; нааш ир! би маргааш өглөө ирнэ; чимээ ирэх;* 2. тохиолдох, болох; *жаргалтай цаг ирэх; гай ирэх; зовлон ирэх; үхэл ирэх;* **сарын юм ирэх** (сарын тэмдэг ирэх); 3. болох, гарах, ирээдүй; *ирэх жил; ирэх зун; өдөр ирэх дутам сайжирсаар байна;* 4. нөхцөл үйл үгийн дагавартай үгийн дараа орж тухайн үйлийн наашлах, ойртох, хүрэхийг заана; *гүйж ирэх; шогшиж ирэх; нисч ирэх; ойртон ирэх; мөлхөн ирэх; цугларан ирэх.*

ИРЭХ II 1. орон савд чихцэн дүүрэх; 2. хэтэртэл идэх, цадах; 3. маш их буюу олны хөдлөх ганхах, найгах.

ИРЭЭД 1. ер орчим, ер шахам; 2. тусбүр ер.

ИРЭЭДҮЙ ирэх болоогүй; *холын ирээдүй; ойрын ирээдүй; ирээдүйн төлөв;* **ирээдүй цаг** (а. болоогүй; б. үйл үгийн цагийг заах төлөвийн нэг).

ИРЭЭДҮЙГҮЙ алс хожимдоо хэрэгцээ багатай буюу хэрэгцээгүй, цаашид ашиггүй; *ирээдүйгүй ажилд цагийг гарздахын хэрэггүй; ирээдүйгүй бодлого.*

ИРЭЭДҮЙТЭЙ алс хожимдоо хэрэгцээтэй буюу хэрэг болохуйц юм; *ирээдүйтэй ажил; ирээдүйтэй үйл явдал.*

ИС I хөө, тортог, чандар; *тогооны ис; зуухны ис.*

ИС II аргүй нэхсэн хар бараан торго.

ИСГИЙ ноос үсээр ширэлдүүлэн хийсэн эд эдлэл; *ахрын исгий; уртын исгий; тохмын исгий; исгий гутал; исгий малгай;* **исгий хэвнэг** (исгийгээр хийсэн цув): **исгийн эх** (а. исгийг анх хийхэд үүсгэн зулсан этгээдийн зах; б. исгий хийхэд дэвсгэрлэн тавьсан исгий); **исгийн бул** (исгийн гол модны хоёр үзүүрт углаж татах нүхтэй мод буюу эврийн нэр, исгийн чих ч гэнэ); **исгийн гол** (исгий хийхэд дунд нь хийж ороох моголцог мод); **исгий татах** (исгий хийж боловсруулахад зулсан ноосыг ороон хуйлж боож баглан мориор зүтгүүлэн өнхрүүлэх); **исгий дарах** (исгийг элдэж боловсруулах).

ИСГҮҮР I 1. маш жижиг хэн хүтгэ; *исгүүр хүтгэ;* 2. хүтганы хүндэтгэл.

ИСГҮҮР II гурил исэлгэхэд хэрэглэхээр дарсны шаргийг гурилтай хольж хөөсрүүлсэн хөрөнгө; **исгүүр хөрөнгө** х о р ш..

ИСГҮҮЛЭХ исгэхийн үйлдүүлэх хэв.

ИСГЭЛЭН айргийн амт мэт амт; **исгэлэн ус** (ногоо жимсний шүүсээр исгэж хийсэн унд); **исгэлэн шүүс** (үр тарианы зүйлээр исгэж хийсэн унд).

ИСГЭРҮҮЛЭХ исгэрэхийн үйлдүүлэх хэв.

ИСГЭРЭХ шүдний завсраар үлээн дуугаргах; *исгэрэн дуудах.*

ИСГЭХ исэхийн үйлдүүлэх хэв, исэхэд хүргүүлэх.

ИСГЭЧИХ байн байн буюу олонт исгэрэх.

ИСЛАМ лалын шашин.

ИСЛЭХ I хөвөн ноосны зэрэг юм сэвсгэр унгарил болох.

ИСЛЭХ II хүйтэнд нүүр чих бага зэрэг хөлдөх, хайрагдах.

ИСЛЭХ III хүчтэй исгэлэн юмны хэт исч хахрах.

ИСМЭГ хүчилтөрөгчтэй химийн махбодын нэгдсэн нэгдэл.

ИСТРЕБИТЕЛЬ 1. сөнөөгч хөлөг онгоц; 2. сөнөөгч нисэх онгоц.

ИСТҮҮЛЭХ истэхийн үйлдүүлэх хэв.

ИСТЭХ истэй болох, ис тогтох; *зуух истэх.*

ИСЭЛ зүгээр, сул; **исэл суух** (сул зүгээр суух).

ИСЭЛГЭХ гурил зэрэг юмыг исгүүр хөрөнгө хольж дулаан газар бүгнэгдүүлэн хөөсрүүлэх; *мантууны гурил исэлгэх.*

ИСЭЛДҮҮЛЭХ исэлдэхийн үйлдүүлэх хэв.

ИСЭЛДҮҮР исэлдэхэд хялбархан бодисууд.

ИСЭЛДЭХ хүчилтөрөгчтэй ямар нэгэн бодисыг нэгтгэх химийн урвал буюу түүнээс устөрөгчийг ялгаруулах.

ИСЭР түшлэггүй мухар сандал.

ИСЭХ юм хувилж хүчтэй амт орох, хахрах; *айраг исэх; тараг исэх.*

ИТ а м ь т а н хуй шаазгайтай адил болоод **арай бяцхан**, сүүл охор, өнгө алаг нэг зүйл шувуу.

ИТГҮҮЛЭХ 1. итгэхийн үйлдүүлэх хэв; 2. итгэгдэх.

ИТГЭГДЭХ итгэхийн үйлдэгдэх хэв, итгэмжтэй болох.

ИТГЭЛ итгэх үйлийн нэр, бат найдлага, сэжиггүй үнэмлэх санаа; **итгэл найдвар** х о р ш.; *бат итгэлт нөхөр; миний итгэлийн орон; итгэл эвдэх; итгэл хүнд; итгэл алдах*

ИТГЭЛГҮЙ итгэх аргагүй, итгэж болшгүй, итгэмж муутай, **найдваргүй**; *итгэлгүй хүний үгэнд бүү итгэ!*

ИТГЭЛТЭЙ бат найдлагатай, итгэвэл зохих, итгэмж сайтай, найдвартай; *итгэлтэй нөхөр; итгэлтэй эм.*

ИТГЭМЖ итгэх санаа, найдлага; *итгэмж найдлага; итгэмж төрөх; итгэмж алдах.*

ИТГЭМЖГҮЙ итгэмжлэх найдваргүй, итгэх **найдлагагүй**; *итгэмжгүй хүнтэй бүү нөхөрлө!*

ИТГЭМЖЛҮҮЛЭХ 1. итгэмжлэхийн үйлдүүлэх хэв; 2. итгэмжлэгдэх.

ИТГЭМЖЛЭГДЭХ итгэмжлэхийн үйлдэгдэх хэв, итгэмжлүүдэх.

ИТГЭМЖЛЭЛ итгэмжлэх үйлийн нэр; *итгэмжлэл сайтай; итгэмжлэл муутай; миний итгэмжлэлийг бүү тэсрүүл!.*

ИТГЭМЖЛЭХ итгэх, найдах, түшиг тулгуур болох; *хэтэрхий итгэмжлэх явдалгүй, итгэмжлэх зүйл байвал итгэж болно;* **итгэмжлэх бичиг** (нэг этгээд нөгөөдөө өөрийн төлөө ямар нэг зүйлийг гүйцэтгэхийг итгэмжлэн олгох бичиг).

ИТГЭМЖТЭЙ баттай, найдвартай; *итгэмжтэй хүнд захижээ.*

ИТГЭХ бат санах найдах, сэжиггүй үнэмлэх; *би чамд итгэнэ; нөхрийн тусламжид итгэх; итгэх сэтгэл төрөх; хүчиндээ итгэх; ялалтад итгэх.*

ИТГЭШГҮЙ итгэхийн арга байхгүй, найдваргүй.

ИХ бага гэдэгтэй эсрэгцэлдсэн утга; 1. хэмжээгээр үлэмж; *их хот; их үстай гол; их говийн зориггон;* **их бие** (хөвчин бие); **их барилга** (шинээр барих барилга; *их барилгын хэлтэс; барилгын төлөвлөгөө);* **их дэлгүүр** (төрөл бүрийн бараа юм худалдах дэлгүүр); **их буу** (сум нь хол газар нисэх нэг зүйл том буу; *танк эсэргүүцэх их буу);* **их бүрээ** (бүдүүн

дуугарах нэг зүйл **үлээвэр хөгжмийн зэвсэг**); **их цэрэг** (а. элдэв зэвсэг бүхий үлэмж цэрэг; б. гол хүчин): **их аюуш** (нэг зүйл том хадаг); **их хураангуй** (ном зохиолын болон түүний бүлэг бүлгийн эцэст дурьдсан зүйлийн товчлон хурааж бичсэн үг); **их наяд** (арван наяд буюу нэг триллион); **их их тэгш** (арван их тэгш буюу тавин найман оронтой тоо); **их тэгш** (тавин долоон оронтой тоо); **их шар цэцэг** ургамал (бут бутаар ургана, навч тойрон ургаж доош сулдайна, цэцгийн төрх хонх мэт, өнгө цагаан, улаан, ногоовтор олон янз, үзвэл уйтгар сэргэдэг гэдэг); **их туулайн бөөр** ургамал (хэмжээ галууны өндөг мэт их, эгшээж иднэ, амт нь туулайн бөөр мэт); **их малига** ургамал (халуун газар ургана, малига цэцэгтэй адил болоод хэлтэс их, өнгө цагаан, үнэр сайхан нэг зүйл цэцэг); **их алаг бялзуухай** амьтан (хөмсөг зурсан адил болоод урт, шар тэрмийн адил өнгөтэй, сэвхтэй, өөр зууraa хэрэлдэх дуртай нэг зүйл бялзуухай); **их бөхгөнө** амьтан (нэг зүйл том батгана); **их хонгор галуу** амьтан (өнгө шар, хушуу хар, бие шонхроос арай бага нэг зүйл шувуу); 2. олон; *хүн их байна; оочир их байна; их мал харагдана;* 3. шилжсэн хүчтэй тун, сүрхий; *их горьдох; их баярлах; их гомдох; их санасан газар есөн шөнө хоосон хонох* зүйр; 4. насанд хүрсэн, том; *их хүн; их болох,* **ихийн шийр барих** (томоотой, хүн шиг явах); *их нь ичиж, бага нь уйлах хуучлах;* **их насны морь** (соёолонгоос дээших насны морь); 5. шилжсэн ах настай; *их ах; их авга; их нагац;* 6. шилжсэн дээд, хүндтэй; *улсын их хурал; эрхэм их сайд; их эрдэмтэн; их дарга;* **их зан** (дээгүүр зан; *их зан гаргах);* **их сургууль** (нийгмийн ба байгалийн шинжлэх ухааны төрөл бүрийн салбар бүхий дээд сургууль; *Улсын их сургууль төгсөв);* **их бичгийн хүн** хуучирсан Хятадын эртний гүн ухааны мэргэжсэн эрдэмтэн буюу тэнгэр газар хүн гурван эрдмийг туулсан хүн); **их хүлгэн судар** шашин (дээд хүлгэний судар); 7. дээд зэрэг, хязгаар нь; *их бодож зодно л биз дээ;* ☆ **их зэрэг сувилах** (цагаан цэцэг өвчин).

ИХДҮҮЛЭХ ихдэхийн үйлдүүлэх хэв, их болгох.

ИХДЭХ 1, хэтэрхий их болох; *бэх уусгахад ус нь ихдэв; зан ихдэх; давс нь ихдэх;* 2, элбэгдэх, томдох, хэтэрхий элбэг, том болох; *гутал ихдэх; ихэдсэн хувцас.*

ИХЖЭЭР залуу бага хүмүүс, их буюу том хүний зан байдалтай. •

ИХСҮҮЛЭХ ихэсгэх, ихсэхэд хүргүүлэх, ихдүүлэх.

ИХСЭХ улмаар их болох.

ИХТГҮҮЛЭХ ихэтгэхийн үйлдүүлэх хэв.

ИХТГЭХ ихдэхийн үйлдүүлэх хэв, улмаар их болгох, ихэсгэх.

ИХТЭХ улмаар их болох.

ИХҮҮРГЭЛ ихүүрэх үйлийн нэр; гутал гутрал; *ихүүргэл төрөх.*

ИХҮҮРГЭЛТЭЙ ихүүргэмээр байдалтай юм, жигшүүрэлтэй, зэвүүрхэлтэй.

ИХҮҮРГЭМ ихүүргэл хүрмээр, дур гутмаар зэвүүцмээр.

ИХҮҮРГЭХ ихүүрэхийн үйлдүүлэх хэв. •

ИХҮҮРЭХ 1. хүний нуршин ярианд дургүйцэл хүрэх; 2. идээний зүйлд нэгшүүрэн дур гутах. •

ИХЭВТЭР арай их, нилээд их.

ИХЭВЧЛҮҮЛЭХ ихэвчлэхийн үйлдүүлэх хэв.

ИХЭВЧЛЭН ихэнх, дийлэнх; *ихэнх нь нэгдлийн гишүүд байв.*

ИХЭВЧЛЭХ үйл ажлын ихэнхийг бүтээж дуусах; *би сургуулиа ихэвчилж байна; ажлаа ихэвчилж чадна; ихэвчлэн ойлгож байв.*

ИХЭД ихээхэн, үлэмжхэн; *ихэд сандрав; ихэд мөрөөдөх.*

ИХЭМСЭГ 1. явдал шудрага төв, зан байдал ёс зүйд нийлэмжтэй сайн; *ихэмсэг сайд; ихэмсэг тушаал;* 2. ихэрхэг; *ихэмсэг түшмэл; ихэмсэг зан.*

ИХЭМСЭГЛЭХ ихэмсэг зан байдал гаргах; *ихэмсэглэн сууж байна.*

ИХЭМСЭГРЭХ ихэмсэг маяг гаргах.

ИХЭНХ дийлэнх, ихээхэн хэсэг, олонхи, зонхи; *гишүүдийн ихэнх хувь нь биеийн тамир хийдэг; ихэнх нь сүү; тариалангийн ихэнхий нь хурааж дууссан.*

ИХЭНХДЭЭ голдуу, олонхидоо; *би ихэнхдээ гэртээ байдаг; ихэнхдээ адил сурлагатай юм.*

ИХЭР 1. нэг эхээс хамт төрсөн нь; *ихэр хурга; ихэр хүүхэд; ихрийн өрөвсөн; хоёр ихэр; гурван ихэр;* 2. ижил хос, адил хос; *энэ хоёр яг ихэр юм шиг санагдана; ихэр гэр;* **ихэр нуруу** (хоёр хэсэг байшингийн үргэлж

нуруу): **ихэр чихэр** (хатуувтар хуурай юмыг зажлахад гарах чимээ); **ихэр шихэр** (аахар шаахар, ялиагүй, аар саар; *ихэр шихэр ажил хийсэн болоод л явж байна);* **ихэр талст** (хос ургасан талст).

ИХЭРЛҮҮЛЭХ ихэрлэхийн үйлдүүлэх хэв.

ИХЭРЛЭХ хүн амьтны хүүхэд зулзага нь хоёр буюу илүү тоотойгоор хамт төрөх.

ИХЭРХҮҮ ихэрхэг зан байдалтай.

ИХЭРХҮҮЛЭХ ихэрхэхийн үйлдүүлэх хэв.

ИХЭРХЭГ их зантай, тоомсоргүй, дээрэнгүй; *ихэрхэг зантай амьтан.*

ИХЭРХЭГЛЭХ ихэрхэг зан гаргах.

ИХЭРХЭХ их зан гаргах, биеэ ихэд бодох; *ихэрхээд уг дуугарч өгсөнгүй.*

ИХЭС I их хүмүүс; **ихэс дээдэс** х о р ш.; *урьд ихэс ноёдын боол болж байв.*

ИХЭС II жирэмсэн хүнд түр байх бөгөөд хэвэл доторхи үрийн тэжээлд нөлөөлөх бүрхэвч; **ихэс түдэх** (хүүхэд төрсний хойно ихэс нь авсаар гарахгүй болох); **ихэс цөглөх** (хүн амьтан төрөөд ихэс нь гарах).

ИХЭСГҮҮЛЭХ ихэсгэхийн үйлдүүлэх хэв, томсгох.

ИХЭСГЭЛ ихэсгэх үйлийн нэр.

ИХЭСГЭХ ихсэхийн үйлдүүлэх хэв, улмаар их болох.

ИХЭЭР I дээгүүр зантай, ихэрхэг; *ихээр хүнд ижил хань ховор.*

ИХЭЭР II их хэмжээгээр; *би ажиллахын ихээр ажиллаж байна.*

ИХЭЭРДЭХ хэтэрхий ихээр болох.

ИХЭЭРЛЭХ ихээр зан гаргах.

ИХЭЭХЭН бааxан, их нилээд их; *миний ажилд ихээхэн саад учирч байна.*

ИЧ 1. солгой гэдэгтэй эсрэгцэлдсэн утга; баруун, зөв; **ич этгээд** (баруун, зөв этгээд); **ич тэгээ** (саадаг зүүх этгээд); 2. санаа явдал сайтар нийлэх; *нэг ич хүмүүс.*

ИЧГҮҮР ичих үйлийн нэр; **ичгүүр сонжуур** х о р ш.; *ичгүүрээ алдсан.*

ИЧГҮҮРГҮЙ ичвэл зохих явдалд ажиггүй аашлах; *ичгүүргүй амьтан.*

ИЧГҮҮРТЭЙ ичгүүр бүхий, ичилтэй, шившигтэй; *ямар ичгүүртэй амьтан бэ, бүү үзэгд!*

ИЧГЭВТЭР ичмээр, сэтгэл зовмоор; ичгэвтэртэй хэрэг.

ИЧГЭЭ ичиг; *ичгээ ичгээ.*

ИЧГЭЭЛҮҮЛЭХ ичгээлэхийн үйлдүүлэх хэв

ИЧГЭЭЛЭХ ичиглэх.

ИЧИГ: ичиг ичиг ичгүүртэй явдал гаргасан хүнийг улмаар ичээхийн тул шоолон өгүүлэхэд хэрэглэх аялга; *ичиг ичиг! яасан муухай юм бэ!*

ИЧИГЛЭХ ичиртэй явдал үйлдсэн хүнийг улмаар ичээхийн тул дооглож „ичиг ичиг" гэж хэлэн гарын хуруунуудыг сарваганууллан дохиолох.

ИЧИГСЭД I ичсэн амьтад; **ичигсэд хөдлөх** (ичсэн амьтад, сэрж ичээндээ хөдлөх).

ИЧИГСЭД II ичгүүртэй бологсод.

ИЧИЛТЭЙ ичвэл зохих, ичмээр

ИЧИМТГИЙ ичих ичингүүрэхдээ хялбар; **ичимтгий аймтгай** х о р ш.; *ичимтгий хүүхэд.*

ИЧИМХИЙ ичимтгий.

ИЧИНГҮҮРЭЛ ичгүүртэй явдал бий гэж буруудаас зовнин дотроо амаргүй болох нь.

ИЧИНГҮҮРЭХ ичих зовних, хэцүүшээх.

ИЧИР ичгүүр, сонжуур.

ИЧИРГҮЙ ичгүүргүй, ичихийг мэдэхгүй; *ичиргүй амьтан.*

ИЧИРТЭЙ ичингүүрэлтэй, ичмээр; *ичиртэй явдлаас зайлж яв!*

ИЧИС а м ь т а н аюулхайдаа эвэртэй нэгэн зүйл амьтан.

ИЧИХ I шоодворлогдом нүүр улайм хэрэг явдалд сэтгэл зовних ,ичингүүрэх; *худал хэлсэндээ машид ичив; ичиж нүүр улайх.*

ИЧИХ II ичигсэд ичээндээ орж хэвтэх; *намар болж тарвага ичив.*

ИЧИХТЭР ичгэвтэр.

ИЧЛЭХ өт шавьж мэтийн овоорон хөдлөх; *шоргоолж ичилж бичилж байв.*

ИЧМЭЭР ичиж зовмоор; *ичмээр юманд ичдэггүй бөх нүүртэй хүн билээ.*

ИЧРЭГ х у у ч и р с а н хүний нууц орон, бэлгэсийн эрхтэн, хүндэтгэлд хэрэглэнэ.

ИЧҮҮР ичгүүр.

ИЧҮҮРГҮЙ ичгүүргүй.

ИЧҮҮРТЭЙ ичгүүртэй.

ИЧЭЭ ичдэг амьтны ичих нүх; *тарваганы ичээ; баавгайн ичээ; амьтан ичээнээсээ гарах цаг.*

ИЧЭЭЛГЭХ ичээхийн үйлдүүлэх хэв, бусдаар ичээх.

ИЧЭЭЛҮҮЛЭХ ичээлэхийн үйлдүүлэх хэв.

ИЧЭЭЛЭХ ичих, ичээндээ орох; *зурам ичээлжээ.*

ИЧЭЭХ I ичих I-ийн үйлдүүлэх хэв, ичихэд хүргүүлэх.

ИЧЭЭХ II ичих II-ын үйлдүүлэх хэв, ичүүлэх.

ИШ I юмны бариул, барих газар; *үзэгний иш; хүрзний иш; цэцгийн иш; жимсний иш;* ☆ **ишит хар** (хөзрийн шомбон хар).

ИШ II 1. үндэс баримт; **иш үндэс, иш баримт** х о р ш.; *иш татах; иш үзүүлэх; ямар ч иш баримтгүй зүйл;* 2. зөвшөөрөл, ёс; *та хэнээс иштэй явж байна? иш зүйд нийлэлцэхгүй явдал; иш олох; иш авах.*

ИШ III онол, чойр.

ИШ IV: **иш чаа бас** өрөвдөх харамсах санаагаа илтгэх үгийн өмнө гаргах аялга үг; *иш чаа бас, даан ч ингэх гэж байх уу, чи.*

ИШ V сарны зурхайн ёсны жилийн өнгө; үүнд улаан-улаагчин, цагаан-цагаагчин, хархарагчин, шар-шарагчин, хөх-хөхөгчин гэх мэт.

ИШИГ ямааны нэг жил болоогүй төл; *ишиг эврээ ургахаар эхээ мөргөх* х у у ч.

ИШИГЛҮҮЛЭХ ишиглэхийн үйлдүүлэх хэв; *ямаа ишиглүүлэх.*

ИШИГЛЭХ ишиг төрүүлэх; *ямаа ишиглэх.*

ИШЛҮҮЛЭХ ишлэхийн үйлдүүлэх хэв.

ИШЛЭХ I юманд иш бариул хийх; *хутга ишлэх; сүх ишлэх; туг ишлэх.*

ИШЛЭХ II иш зөвшөөрөл авах.

ИШЛЭХ III уллах ,суурилах; *хашир хүн гэсэндээ ишилж байна.*

К

К монголын цагаан толгойн үсэг, К авиа, К үсэг; жинхэнэ монгол үгэнд хэрэглэхгүй.

КАБИН уурын тэрэг, нисэх онгоц зэрэгт жолоочийн суух тусгайлсан өрөө; *машинын кабин дотор.*

КАБИНЕТ I 1. ажлын өрөө, тасалгаа; *эрдэмтний кабинет; утга зохиолын кабинет; намын кабинет;* 2. тусгай ажилд зориулан тоноглосон газар; *физикийн кабинет; шүдний кабинет.*

КАБИНЕТ II зарим орны засгийн газар багтан ордог сайд нарын бүрэлдэхүүн.

КАГОР нэгэн зүйл улаан дарс.

КАДЕТ 1. х у у ч и р с а н гадаад оронд цэргийн дунд боловсролын сургуульд хүмүүжин сурагч; 2. Орос оронд хувьсгалын өмнө „ардчилсан үндсэн хуульт нам" гэдгийн буржуйлиг намын гишүүн, 1917 онд хувьсгалын эсэргүү хөдөлгөөнийг толгойлжээ.

КАЗАХ хасаг; *казах хэл.*

КАКАО у р г а м а л 1. халуун орны мод, үрээр нь шоколад буюу бурам чихэр хийнэ; 2. сайхь үрийг нухсан нунтаг, үүгээр унд хийж цай шиг ууна; *нэг шаазан какао; лаазтай какао.*

КАЛЕНДАРЬ цаг тооны бичиг; *ширээний календарь; ханын календарь.*

КАЛЕНДАРЧЛАХ өдөр өдөрт зохицуулах; *календарчилсан төлөвлөгөө.*

КАЛИ химийн үндсэн махбод, мөнгөн цагаан өнгөтэй, зөөлхөн төмөрлөг; *калийн шүү.*

КАЛИБР 1. галт зэвсгийн гол төмрийн нүхний диаметр; 2. жижиг калибрын буу; *калибрын сум.*

КАЛОРИ дулааны хэмжээг тодорхойлох илчийн нэгж.

КАЛОШ ус чийг, шавраас хамгаалан гутлын гадуур өмсөх резинээр хийсэн шаахай, галош ч гэнэ; *калош өмсөх.*

КАЛЬЦИ химийн үндсэн махбод, хөнгөн цагаан төмөрлөг.

КАМЕР хий хөөрцөгдөн оруулах резин уут; *дугуйны камер* (дугуйн доторхи).

КАМЕРТОН хөгжмийн хөгийг нийлүүлэх, дуу дуулах зэрэгт үндсэн хөг болгох дуу гарах болд ац.

КАМПАНИ 1. нийгэм улс төрийн буюу аж ахуйн ээлжит чухал зорилтыг биелүүлэхийн тул явуулах арга хэмжээ; *сонгуулийн кампани; тариалангийн кампани;* 2. нөгөө талын эсрэг зохион байгуулсан эвсэл.

КАМПАНИЧЛАХ кампани зохиох.

КАМФОР гавар.

КАНДИДАТ 1. сонгууль буюу ямар нэгэн ажилд олон нийтийн нэр дэвшүүлсэн хүмүүс; 2. эрдмийн дэд зэрэг.

КАПИТАЛ ажилчдын хөдөлмөрийг мөлжих замаар нэмүү өртгийг олж авдаг капиталистуудын зэвсэг нь болох өртөг, үйлдвэрлэлийн хэрэгсэл; *үйлдвэрийн капитал; санхүүгийн капитал.*

КАПИТАЛИЗМ үйлдвэрлэлийн хэрэгслийг капиталистууд өмчилж, ажилчдын хөлсний хөдөлмөрийг сорон мөлжихөд тулгуурлан тогтсон тийм нийгэмлэгийн байгуулал; *капитализм мөхөж, коммунизм ялах нь гарцаагүй; капитализмын салшгүй замын хань нь ажилгүйдэл, ажилчны үгүйрэл хоосрол мөн.*

КАПИТАЛИСТ буржуйлиг нийгэмлэгийн ноёрхох ангийг төлөөлөгч, хөлсний хөдөлмөрийг мөлжигч, капиталын эзэн, ардчилал ба хөдөлмөрчдийн ашиг тусад харш дайсан этгээд; *капиталистуудын өдөөн хатгалга.*

КАПИТАЛТАН хөрөнгөтөн.

КАПРОН нэг зүйл хиймэл ширхэг, мөн тийм ширхгээр нэхсэн маш сайн чанарын нэхмэл бараа; *капрон оймс.*

КАРАБИН морин цэргийн богино винтов буу.

КАРАКУЛЬ 1. хонины нэг үүлдэр; 2. мөн хонины хурганы арьс.

КАРАМЕЛЬ хатуу чихэр, цаастай чихэр.

КАРАНТИЙЛАГДАХ карантийлахын үйлдэгдэх хэв.

КАРАНТИЙЛАХ карантийн тогтоох, хориг тогтоох; *өвчтэй малыг карантийлах.*

КАРАНТИЙЛУУЛАХ 1. карантийлахын үйлдүүлэх хэв; 2. карантийлагдах.

КАРАНТИН 1. хөл хорих, халдварт өвчтэнтэй холилдсон буюу тахал өвчнөөр өвчилсөн амьтныг түр тусгаарлах *карантинд орох; карантин тавих;* 2. өвчин тахал гарсан газраас ирэгсдийг ариун цэврийн талаар шалгаж үзэх цэг.

КАРБОЛ: карболын хүчил халдвар үгүйтгэх хахуун шингэн зүйл, чулуун нүүрс хүлрийг хуурай нэрэхэд гарах зүйлсийн нэг.

КАРБЮРАТОР дотор нь карбюрац болох хэрэгсэл.

КАРБЮРАЦ шингэн түлш агаар хоёр нийлж, шатах хольцоо тогтох (дотуур шатах хөдөлгүүрт).

КАРМАН халаас; *цамцны карман.*

КАРТ 1. газрын зураг; 2. шошго; *карт хийх; картнаас хуулан авах;* 3. юм авах талонтай хуудас; *дайны цагийн идэш уушны карт; картын системийг зогсоох;* **картын систем** (дайны хүнд үед бараа таваар, идэш уушны зүйлийг хөдөлмөрчдөд тэгш хуваарлан олгохын тул тусгай тасалбар олгох журам).

КАРТЕЛЬ зах зээлд ноёрхох, өндөр ашиг олох, хөдөлмөрчдийг мөлжих явдлыг нэмэгдүүлэхийн тулд томхон аж үйлдвэрийн аль нэг салбарыг нэгтгэн удирдах хөрөнгөтний монополийн хэлбэр.

КАСС 1. албан үйлдвэр, худалдааны газруудад мөнгө хураах, хадгалах, олгох ажлыг эрхлэх өрөө, тасаг; *дэлгүүрийн касс; төмөр замын касс; театрын касс;* 2. зүйл бүр зээллэгийн газрын нэр; *зээл олгох касс; хадгаламжийн касс; нийгмийн даатгалын касс;* **зээлдэн туслах касс** (голдуу гишүүдийн татвараар хуримтлуулсан мөнгөөр гишүүддээ тусламж үзүүлэх зорилгоор хоршооллосон нэгдэл); 3. хэвлэлийн үсэг бүхий хайрцаг; *үсгийн касс.*

КАССАЧ кассын ажлыг эрхлэх хүн.

КАССЕТ ялтасны хайрцаг (гэрэл зургийн хальсны).

КАТАЛОГ ном, үзмэр, эд бараа зэрэг нэг төрлийн юмсын нэрсийг зохих журмаар эмхэтгэсэн жагсаалт; *үсэг дараалсан каталог; каталогийн хайрцаг.*

КАТЕГОРИ ай, бүлэг, аймаг, зэрэг, шат.

КАТЕТ эгц өнцөгт гурвалжны эгц өнцөг таргах хоёр талын нэг.

КАТОЛИК: католик шашин христос шашны нэг салбар, *католик шашин бол харгис ёс, мухар сүсгийн түшиг тулгуур мөн.*

КАТУШКА ороомог, сүлжээ.

КАУЧУК боловсруулж резин хийх зарим ургамлын сүүн шүүс.

КАФЕДР тэнхэм; *химийн кафедр; кафедрын эрхлэгч.*

КАША агшаамал, чанасан будаа.

КВАДРАТ дэрвэлжин.

КВАС жимс зэрэг юмаар хийх исгэлэн ундаан.

КВИТАНЦИ мөнгө буюу бусад үнэт эдлэл авсан тухайд олгох албан баримт; *мөнгөний квитанци.*

КЕРОСИН нефть нэрэхэд гарах шатах шингэн зүйл; *керосин лампа.*

КИЛО килограмм; *нэг кило элсэн чихэр авна.*

КИЛОВАТТ цахилгаан гүйдлийн хүчний нэгж, нэг мянган ваттай тэнцүү; *арван киловатт.*

КИЛОГРАММ хүнд хөнгөний хэмжүүр, нэг мянган граммтай тэнцүү; *таван килограмм цагаан будаа.*

КИЛОМЕТР уртын хэмжүүр; нэг мянган метртэй тэнцүү; *нэг өртөө газрыг гучаад километр гэдэг.*

КИНО дэлгэц дээр сүүдэр зураг үзүүлэх үзмэр; *кино зураг; монгол кино; кино найруулагч; дуутай кино; өнгөт кино; кино үйлдвэр; кино жүжигчид; нүүдлийн кино; суурин кино; кинонд очих;* **кино зураг** (киноны дүрс зураг бүхий нарийн хальс).

КИНОАППАРАТ кино зураг авах, кино гаргах аппарат.

КИНОМЕХАНИКЧ кино гаргах мэрэгжилтэй хүн; *киномеханикчдый зөвлөлгөөн; тэргүүний киномеханикч.*

КИНОСТУДИ кино зургийн газар, кино үйлдвэр,

КИНОТЕАТР кино үзүүлэх театр; *аймгийн кинотеатр.*

КИНОФИЛЬМ кино зураг.

КИНОФЕСТИВАЛЬ нэг улсын кино зургийг зориуд үзүүлэх нь; *Монгол-Зөвлөлтийн найрамдлын сарыг тохиолдуулан Зөвлөлтийн кинофестиваль явагдав.*

КИСЕЛЬ шингэн цэлцэгнүүр идээ; *сүүн кисель; жимсэн кисель.*

КИСЛОТА хүчил; *азотын кислота.*

КИТЕЛЬ дүрэмт хувцас, босоо захтай гадуур цамц.

КЛАПАН механизмын нэг хэсэг; уур, хий, шингэн зүйлийг үл нэвтрүүлэх таглаа мэт зүйл.

КЛАССИК сонгодог; *классик зохиолууд; классик бичгийн хэл.*

КЛАССИКЧ онцгой, гайхамшиг, даяарт алдаршсан, давшилт шинжлэх ухаан, урлаг, утга зохиолын гарамгай зүтгэлтэн.

КЛИНИК эрдэм шинжилгээний ба сурган боловсруулах ажлыг хавсран явуулдаг эмнэлгийн газар.

КЛУБ соёл гэгээрэл, улс төр, биеийн тамирын зэрэг ажил зохион явуулах олон нийтийн байгууллага; *нэгдлийн клуб; шатрын клуб.*

КОВЕРКОТ сайн чанарын нэг зүйл ноосон даавуу.

КОКС чулуун нүүрс буюу хүлрээс гарах хатуу зүйл, түлшинд хэрэглэнэ.

КОКСЛОХ кокс болгох; *нүүрс кокслох.*

КОЛБАСА хиам; *утсан колбаса; түүхий колбаса.*

КОЛЛЕГИ тусгай тогтоосон хэсэг хүмүүсээр бүрэлдсэн захирч тушаах, зөвлөх байгууллага; *Гэгээрлийн Яамны коллеги; коллегийн гишүүн.*

КОЛЛЕКТИВ хамт олон.

КОЛЛОИД үл талсталагдах эд, уусмал нь амьтан ургамлын хальсыг нэвтрэхгүй; *коллоид эд.*

КОЛОНИ империалист улсад хүчээр эзлэгдэн, мөлжигдөн дарлагдаж байгаа орон; *колонийн дарлал; колонит гүрэн.*

КОЛОНИЧЛОГДОХ колоничлохын үйлдэгдэх хэв, колонийн дарлалыг амсах.

КОЛОНИЧЛОГЧ колонийн ард түмнийг дарлан мөлжигчид, боолчлогчид.

КОЛОНИЧЛОЛ империалистууд аль нэг орныг колони болгож эзэмшин авах явдал; *колоничлолыг устгах.*

КОЛОНИЧЛОХ харийн орныг хүчээр эзлэн авч, колони болгож дарлан мөлжих.

КОЛОНИЧЛУУЛАХ 1. колоничлохын үйлдүүлэх хэв; 2. колоничлогдох.

КОЛОНКА авто тээвэрт шингэн шатахууны тавьж олгох газар; *бензиний колонка.*

КОМАНД 1. тогтсон маягаар хэлэх ам тушаал; *командаар алхах;* 2. захиргаа, мэдэлд; *энэ ямар даргын командад явааа хүмүүс вэ?* 3. отряд, цэргийн жижиг анги, баг; *гал команд;* 4. хөлөг онгоцны ажиллах хүмүүс; *галт онгоцны команд;* 5. биеийн тамирын баг; *волейболын команд.*

КОМАНДЛАГЧ цэргийн ангийн дарга; *хороо командлагч.*

КОМАНДЛАЛ 1. командлах үйлийн нэр; 2. цэргийг захирах толгойлох хүмүүс; *дээд командлал; армийн командлал.*

КОМАНДЛАХ 1. команд өгөх; *«номхон!» гэж командлав;* 2. даргалах, захирах; *хороо командлах.*

КОМАНДЛУУЛАХ 1. командлахын үйлдүүлэх хэв; 2. командлагдах.

КОМБАЙН үр тариаг өөрөө хадаж, хурааж, цайруулах хөдөө аж ахуйн машин; *комбайны жолооч; «СК-3» комбайн.*

КОМБАЙНЧ комбайны жолооч.

КОМБИНАТ 1. элдэв үйлдвэрийн салаа мөчрийг нэгтгэсэн аж үйлдвэрийн газар; *аж үйлдвэрийн комбинат;* 2. янз бүрийн мэрэгжлийн сургуулийн нэгдэл; *сургуулийн комбинат.*

КОМБИНЕЗОН өмд цамц хоёрыг үргэлж хийсэн гадуур өмсөх ажлын хувцас.

КОМЕНДАНТ 1. цайз буюу бэхэлсэн нутаг районы бүх цэргийн захирал; 2. гарнизоны албыг зөв хааж байгаа эсэх; сахилга бат, журам дэглэмийг нарийн чанд сахиж байгаа эсэхийг хянах тушаалтан; *хотын комендант; лагерийн комендант;* 3. цэргийн ачаа хэрэгслийг зөв зохистой тээж байгаа эсэхийг хянаж шалгах этгээд; 4. нийтийн орон байшингийн эрхлэгч; *нийтийн байрны комендант.*

КОМИНТЕРН коммунист интернационал; *коминтерны төвийн гүйцэтгэгч хороо.*

КОМИСС I албан газар, байгууллагын дэргэд тусгайлан бүрэн эрхтэй гарсан хэсэг хүмүүс буюу хэсэг хүмүүсээр бүрэлдсэн байгууламж; *тооллогын комисс; сонгуулийн комисс; шалган байцаах комисс.*

КОМИСС II зохих хөлсөөр гүйцэтгэх даалгавар; *эд барааг комисст авах; комиссын дэлгүүр.*

КОМИССАР нийгэмлэг, улс төр, засаг захиргааны зэрэг үйл ажлыг удирдах; тушаалтан; *цэргийн комиссар.*

КОМИССЛОГДОХ комисслохын үйлдэгдэх хэв, гологдох. шаарлагдах.

КОМИССЛОХ комисст үзүүлэх; *барилгын ажилд тэнцэх эсэхийг комиссолж байна.*

КОМИССЛУУЛАХ 1. комисслохын үйлдүүлэх хэв; 2. комисслогдох.

КОММУН эд хөрөнгө, ажил хөдөлмөрөө нэгтгэж хамтран амьдрахаар нэгдсэн хүмүүс; *хөдөлмөрийн коммун; хөдөө аж ахуйн коммун;* ☆ **Парисын Коммун** (1871 онд Парис хотод бослого гаргасан хөдөлмөрчин олны хувьсгалт засаг; *Парисын коммун бол пролетарийн дарангуйлан захирах засгийг тогтоох гэсэн анх удаагийн оролдлого байжээ*).

КОММУНИЗМ эвхамт ёс; пролетарийн хувьсгал, пролетарийн дарангуйлан захирах засгийн ялалтын үрээр капитализмын оронд бий болох нийгэмлэгийн байгуулал бөгөөд түүний үйлдвэрлэлийн харьцааны үндэс нь анги гэж ялгаварлах явдал байхгүйгээс гадна хот тосгон хоёр хийгээд оюуны ба биеийн хөдөлмөр хоёрын хоорондын ялгаа арилсан, хувиарлалыг хэрэгцээний хирээр гүйцэтгэх зарчим болно; *нийгэм журам бол коммунизмын анхдугаар шат мөн; коммунизмын зарчим нь «хүн бүрээс чадварынх нь хирээр, хүн бүхэнд хэрэгцээнийх нь хирээр» гэдэг зарчим юм;* ☆ **балар эртний коммунизм** (балар эртний хүний нийгэмлэгийн ангийн урьдах байгуулал бөгөөд үйлдвэрлэлийн хэрэгсэл ба бүтээгдэхүүн нь нийтийн өмч байжээ); **цэргийн коммунизм** (Октябрийн нийгэм журамт их хувьсгалын 1921 он хүртлэх, эхэн үеийн нэр болно).

КОММУНИСТ 1. коммунист намын гишүүн хүн; 2. коммунизмын үзэл санаа нэвтэрсэн, түүнийг илэрхийлсэн нь; *коммунист нам; хөдөлмөрт коммунист ёсоор хандах; коммунист хумуужил.*

КОММУТАТОР 1. цахилгаан тогийг сэлгүүлэн явуулах хэрэгсэл; 2. телефон утасны аппаратуудыг залгах төхөөрөмж.

КОМПАНИ 1. хэсэг хүмүүс, хоршоолол, эвсэл; 2. хөрөнгөтөн орны үйлдвэр худалдааны эздийн нэгдэл; *машины үйлдвэрийн компани.*

КОМПАНИДАХ хамтрах, нийлэх, эвсэх.

КОМПАС луужин.

КОМПОЗИТОР хөгжмийн зохиолч, найруулагч.

КОМПОТ усанд чанасан жимсээр хийсэн амттай шингэн идээ.

КОМПРЕСС жин IV.

КОМСОМОЛ Бүх Холбоотын Лениний коммунист залуучуудын эвлэл.

КОНВЕЙЕР үйлдвэрийн газарт боловсруулж байгаа зүйлийг нэг ажилчнаас нөгөөд тасралтгүй дамжуулан хүргэх буюу эсвэл ачаа зөөхөд зориулсан дамжлага; *конвейерын систем.*

КОНВЕРТ дугтуй.

КОНГРЕСС 1. олон улсын ач холбогдол бүхий асуудлыг шийдвэрлэх хурал цуглаан; 2. зарим улсын парламентын нэр.

КОНДЕНСАТОР 1. цахилгааныг цуглуулан хураадаг хэрэгсэл; 2. уурыг ус болгодог хэрэгсэл.

КОНДУКТОР галт тэрэг, автобус зэрэг тээврээр зорчигсдыг үйлчлэх ажилтан; *галт тэрэгний кондуктор; автобусны кондуктор.*

КОНСЕРВ удаан хадгалахад зориулж хөлдөөх, хатаах, давслах зэргээр боловсруулсан идээ; *загасны консерв.*

КОНСЕРВЛОХ идээний зүйлийг консерв болгох.

КОНСЕРВЛУУЛАХ консервлохын үйлдүүлэх хэв.

КОНСПЕКТ товчлол; *хичээлийн конспект; Монголын намын түүхийн конспект.*

КОНСПЕКТЛОХ конспект хийх.

КОНСПЕКТЛУУЛАХ конспектлохын үйлдүүлэх хэв.

КОНСУЛ харь улсын орон нутгийн засаг захиргааны өмнө өөрийн улс ба ард иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах элчний газрын албан тушаалтан; *ерөнхий консулын газар.*

КОНСУЛЬТАЦ зөвлөлгөө; *консултац авах; консултац өгөх.*

КОНСТРУКТОРЧ зохион бүтээгч; *нисэх онгоцны конструктор.*

КОНСТРУКЦИ хийц, бүтэц, байгуулалт.

КОНТАКТ нийллэг, нийлэх, хүрэх, хүрэлцэх.

КОНТОР албан үйлдвэрийн газрын засаг захиргаа, бичиг хэргийн хэлтэс тасаг ба мөн их төлөв аж ахуй, санхүүгийн чанартай биеэ даасан газрын нэр; *үйлдвэрийн газрын контор; шуудангийн контор.*

КОНТОРЛОХ конторт сууж албан ажил хийх.

КОНТОРЛУУЛАХ конторлохын үйлдүүлэх хэв.

КОНТРОБАНДА бараа таваарыг гайль хураалгалгүй нууцаар хил давуулах нь.

КОНЦЕРН капиталист оронд үйлдвэрийн газруудыг нэг буюу хэд хэдэн том капиталистын мөнгөн санхүүгийн удирдлагад монопольчлон нэгтгэх нь.

КОНЦЕРТ хөгжмийн зэрэг бусад зохиолыг нийтэд үзүүлэх; *концерт үзэх; яруу тунгалаг найрал хөгжмийн концерт;* **концерт хөтлөгч** (концертыг хөтөлбөрийн дагуу журамлан явуулагч); **концертын программ** (концертын хөтөлбөр).

КОНЦЕССИ нэг улсаас нөгөө нэг улс буюу хүнд уурхайн баялаг, үйлдвэр, газар олгож тодорхой хугацаанд ашиглуулах хэлэлцээ; *концесси олгох.*

КОНЦЕССИЧ концессийн эзэн.

КОНЬКИ тэшүүр; *конькигоор гулгах; конькигоор явах.*

КОНЬЯК усан үзмийн спиртээр хийсэн дарс.

КООПЕРАТИВ хоршоо, хоршоолол.

КООПЕРАЦ хоршоо, хоршоолол; *Лениний коперацын төлөвлөгөө.*

КОРИДОР орон байшингийн энэ тэр хэсгүүдийг хооронд нь холбосон нарийн гудам.

КОРПУС цэргийн том нэгдэл; *танкийн корпус.*

КОРРЕКТОР үсэг хянагч.

КОСМОПОЛИТИЗМ бүх дэлхийг өөрийн эх орон гэж хуурмаглан мэхэлж, үндэсний соёлын эрхэм чанарыг үл ойшоон, үндэсний биеэ дааж оршин тогтнох эрх, эх орон хийгээд улсын тусгаар тогтнолыг хамгаалах үзэл санааг хэрэггүйд тооцох, эх орончч үзлийн эсрэг буржуйлиг харгис үзэл.

КОСТЮМ эрэгтэй эмэгтэй хүний европ маягийн гадуур өмд цамц; *костюм өмсөх.*

КОТЛЕТ татсан мах, ногоо, будаа зэргээр бөөн хэсгээр шарсан хоол; *төмсөн котлет.*

КОФЕ 1. кофейн мод гэдэг халуун орны модны бөөрөнхий үр; 2. энэ үрээр чанасан унд.

КОФЕЙН кофийн үр, цайны навч гаргах авах сэргээх чанарын бодис.

КОЭФФИЦЕНТ 1. томьёоны ухааны илэрхийллийн үржүүлэгч тоо; 2. физикийн ямар нэгэн биеийн чанарыг тодорхойлох хэмжигдэхүүн.

КРАН I цорго.

КРАН II хүнд ачаа ачих, буулгах, өргөх өргүүр механизм.

КРЕДИТ зээл.

КРЕДИТОР зээл олгогч, зээлдүүлэгч.

КРЕЙСЕР далайн байлдааны том хурдан хөлөг онгоц.

КРЕПДЕШИН нэг зүйл торгон бөс.

КРИЗИС капиталист нийгэмлэгийн эдийн засаг, төрийн үйл хэрэгт үе үе тохиолдох хямрал.

КУБ 1. шоо дөрвөлжин; 2. ямар нэг тооны гурван зэрэг; *куб зэрэг дэвшүүлэх;* ☆ **куб татах** (кублэсэн мод татах); **куб хураах** (мод кублэх).

КУБЛҮҮЛЭХ кублэхийн үйлдүүлэх хэв.

КУБЛЭХ дөрвөлжин болгож хураах; *мод кублэх; чулуу кублэх.*

КУБМЕТР шоо дөрвөлжин метр.

КУЛЬТИВАТОР газрын хөрсийг сэвсгэр болгох зэвсэг.

КУРС 1. ямар нэгэн мэрэгжилд суралцах бүрэн систем; *санхүүгийн курс төгсгөв;* 2. дээд сургуулийн жил жилээр шаталсан анги; *дөрөвдүгээр курсэд орох; хоёрдугаар курс практик хийж байна;* 3. эмнэлгийн хугацаа бүхий зүйл; *нэг курс тариа хийх.*

Л

Л I монголын цагаан толгойн үсэг; Л үсэг, Л авиа.

Л II хүч нэмэгдүүлэх үг; *авбал л ав; над өг л дөө; дуртай л байна; хэцүү л хүн шүү; мэдэж л бай; горигүй л болсон байх даа; явах нь л зайлшгүй болов.*

ЛАА (Н) I 1. дотроо голтой гонзгор тослог зүйл, асааж гэрэл болгон хэрэглэнэ; *лаа барих; лааны тос;* **лааны гол** (ноцоох утас); **лааны суурь** (лааны хатгуур): **лааны тавиур** (лааны суурь); **лааны хатгуур** (лаа хатгах суурь); **лааны хэв** (лаа чутгах хэв); 2. аливаа эх булаг бүхий гэрлийн хүчийг хэмжих нэгж; *зуун лааны гэрэлтэй чийдэнгийн шил;* 3. эмнэлэгт хэрэглэх бяцхан гоожуур тослог зүйл.

ЛАА II: лаа лаа лаа юмыг муухай бузар, шившигтэй гэх зэрэгт хэрэглэх аялга; *лаа лаа лаа, муухай, битгий тэг!*

ЛААВ галт уул дэлбэрч оргилоход дээш гарч ирэх эрдэс зүйлийн хайлмал; *галт уулын лаав.*

ЛААГАЛДАХ шигүү няг, өтгөн, зууралдсан юман дундуур мацалхийлан явах, зүдүүрэх; *цасан дундуур лаагалдаж яваад ирэв; шугуйгаар лаагалдаж арай чарай нэвтрэн гарав.*

ЛААГАЛТАХ юмны өтгөн, лаагуу, заваан байдалтай болох; *лаагалтсан хоол идэж орхив; цас лаагалтах.*

ЛААГУУ өтгөн, заваан зуурмаг юм; *лаагуу хоол; лаагуу цас шавар.*

ЛААЗ юм агуулах төмөрлөг сав; *усны лааз; бензиний лааз; чихрийн лааз; консервны лааз.*

ЛААХАЙ тулгасан найдлага; *лаахай шаах; яахыг чи л мэд гэж ах над хүүхдээ лаахай шааж орхиод явав.*

ЛААХАЙДАХ юмыг хэтэрхий тулган найдах; *над лаахайдахын хэрэггүй.*

ЛААХАЙЛАХ юмыг найдаж тулгах; *над лаахайлаад юу хийнэ.*

ЛАБОРАНТ лаборатори ба шинжилгээний газрын эрдэм шинжилгээний техник ажилтан; *туршилт авиа зүйн лабораторийн лаборант.*

ЛАБОРАТОРИ сорилтын тийхэм; *лабораторийн шинжилгээ.*

ЛАВ I 1. гүнзгий, гүн; *зүүгээр лав хатгах; лав эсгэх;* 2. мөчид биш, цаагуур, бат бөх; *лав барих; лав орох; лав уях;* 3. шилжсэн магад, үнэн, хуудуугүй, хуумгай биш; *лав хэлэх; лав үнэн; лав мэдэнэ;* **лавы нь олох** (үнэн ма-

гадыг олж мэдэх); 4. тааж таамаглах; *лав тийм биз ээ; лав сонссон байх аа.*

ЛАВ II: **лав зул** лаа.

ЛАВ III юм наах бэхлэхэд зориулсан лац мэт бөгөөд зөөлөн наалдангир зүйл; *хөөрөгний толгойг лаваар наадаг; ногоон лав; улаан лав.*

ЛАВ IV: **лав тос** газраас гардаг нэг зүйл тос, лаа хийдэг, эмнэлэгт хэрэглэнэ.

ЛАВ (АН) V зөгийн биенээсээ гаргаж үүр барих юм, мөн түүнтэй адил ургамлын эдийн тос.

ЛАВ VI зам цардах зэрэгт хэрэглэдэг наалдангир байдалтай юм; *хадны лав; алт мөнгөний дархны хэв хийх лав.*

ЛАВАА I а м ь т а н намрын цагт голд унах нэг зүйл цагаан хорхой.

ЛАВАА II а м ь т а н хуурамч тор жигүүрт шавьжийн нам, зулзага нь усанд хэдэн жил оршино, нас гүйцсэн хойно амгүй шавьж болж хувилна, гэдэс ормын төдий, саг орхимогц үхдэг нэг зүйл хорхой.

ЛАВААЗ чулуу засах багаж.

ЛАВАЙ I бүрээ хорхойн хальс яс; *дун лавай; цагаан лавай; лавай үлээх.*

ЛАВАЙ II у р г а м а л элсэрхэг говь газар ургадаг олон наст бут ургамал, шар ногоовтор цэцэгтэй, эрвээхэй мэт хэлбэртэй үртэй, хоёр зүйл бий.

ЛАВАЙЧ лавай үлээхэд дадамгай хүн.

ЛАВАР: лавар мод у р г а м а л халуун орны мөнх ногоон мод, навч анхилуун үнэртэй; *лавар модны навч.*

ЛАВД тодорхой, илэрхий.

ЛАВДАЛ: лавдал цэцэг у р г а м а л навч том, таван хэлтэстэй, өнгө хув мэт шар, доош унжийж цэцэглэнэ.

ЛАВДАХ I юмыг лаваар шавах, лав түрхэх.

ЛАВДАХ II хэтэрхий лав болох.

ЛАВДЛАХ юмны уг туйлыг олж мэдэх; *лавдлан мэдэх; лавдлан таних; лавдлан магадлах.*

ЛАВДУУ I арай лав, нилээд лав.

ЛАВДУУ II төлөв томоотой, даруу зантай.

ЛАВДУУЛАХ лавдахын үйлдүүлэх хэв.

ЛАВДУУХАН арай лавхан, нилээд лавхан.

ЛАВИР юмны дээгүүр хөндлөн ташаалан зүүх чимэг.

ЛАВРИ шашны ёсонд: бурхан, хувилгаад, лам нарын суух суудал, орны дээгүүр татах нэгэн зүйл чимэг хэрэглэл.

ЛАВЛАХ I 1. дахин магадлах, асуух; **асуух лавлах** х о р ш.; *сайн лавлах хэрэгтэй;* **лавлах бичиг** (мэдэхийг хүссэн зүйлийг олж үзэх ном; *утасны лавлах бичиг; анагаах ухааны лавлах бичиг*); 2. асуусан хүссэн зүйлд харин өгөх газар; *лавлах товчоо; утасны товчоо; утасны дугаарыг лавлахаас асуух хэрэгтэй;* 3. лав барилцах; **лавлан барилцах** (бөх нарын барьц авах).

ЛАВЛАХ II 1. яр шархны бээрлэсэн газрыг цоолж цус идээ гаргах; 2. нимгэн юмыг цоолох.

ЛАВЛУУЛАХ лавлахын үйлдүүлэх хэв.

ЛАВМАГ техник болон өргөн хэрэгцээний зүйл хийдэг хиймэл эд.

ЛАВРАХ 1. бугласан яр шарх хагарах; *шарх лаврах;* 2. шингэн юм агуулсан зөөлөн сав цоорч язрах; *гүзээ лаврах; хөхүүр лаврах;* 3. нимгэн зөөлөн эд юм сэмрэн цоорох; *дээл лаврах; бүс лаврах.*

ЛАВРИН х у у ч и р с а н хутагт хувилгаад лам нарын суух байшин; *сэрүүн лаврин.*

ЛАВС малгайлан орсон цасны том ширхэг; *лавс цас орж байна.*

ЛАВСАА лавсан орсон цас.

ЛАВСАХ цас малгайлан орох; *цас лавсах; утаа лавсах; лавсах баагих.*

ЛАВТАЙ магадтай, үнэнтэй; *лавтай мэдээ иржээ.*

ЛАВТАЙХ 1. навтайх, бөхийх; 2. ш и л ж с э н бие улбас болон ядарч хэвтэх.

ЛАВТРАХ навтрах, тамтаггүй элэх; **лавтар савтар** х о р ш..

ЛАВХ нумны зэв сум агуулах арьсан сав.

ЛАВХАН арай лав, баахан лав.

ЛАВШАА 1. нялх амьтны эхийгээ хөхөхөд хэтэрхий ховдог; *лавшаа хурга;* 2. ш и л ж с э н дэмий ярих дуртай, яриа; *лавшаа хүн.*

ЛАВШИГ захгүй ёст дээл.

ЛАВШИХ I логших, юмыг ширмэглэн товшиж оёх; *эсгий лавших; дээл лавших.*

ЛАВШИХ II 1. сайн мууг санахгүй, санаандаа орсныг ярих, хэлэлцэх; 2. зарим амьтны хоолоо ховдоглон түргэн идэх.

ЛАВШРАХ юмны улам лав болох.

ЛАВШРУУЛАХ лавшрахын үйлдүүлэх хэв, лавшрахад хүргүүлэх.

ЛАГ I: **лаг шороо** усны ёроол дахь шавранцар шингэн шороо.

ЛАГ II: **лаг мэлхий** амьтан яст мэлхийтэй адил бөгөөд дүгрэг биетэй, урт хүзүүтэй, сүүл охор, хавтас тойрон сэхүүртэй, махы нь идэж болно.

ЛАГ III: **лаг буух, лаг суух, лаг хийх** хүнд юмны нүргээнтэй, нүсэр буух, унах.

ЛАГА I амьтан цах хорхойд адил **бөгөөд** бяцхан, далавчтай, зуны цагт дуугарах **нэгэн** зүйл хорхой.

ЛАГА II: **лага яр** хүний толгойд гарна, хатигаас ихээхэн нэгэн зүйл яр.

ЛАГАЙ буддын шашны гэлэн хүний гадуур нөмрөх нэгэн зүйлийн номын хувцас, номт дээл ч гэдэг.

ЛАГАЛДАХ дэндүү өтгөрч зууралдах; *лагалдсан хоол; лагалдсан шавар.*

ЛАГАЛДУУЛАХ лагалдахын үйлдүүлэх хэв.

ЛАГАР завьяа модны төрлийн нэг зүйл мод.

ЛАГЕРИЛАХ түр зуурын зусланд гарах; *манайх уулын аманд лагерилах гэж байна.*

ЛАГЕРИЛУУЛАХ лагерилахын үйлдүүлэх хэв.

ЛАГЕРЬ 1. суурин хүмүүсийн түр зуурын зуслан; *пионерийн лагерь; цэргийн лагерь;* 2. нийгэм-улс төрийн талцаа; *энх тайвны лагерь; ардчилал, социализмын лагерь.*

ЛАГЛАГАР бие бүдүүн лахгар.

ЛАГЛАЙЛГАХ лаглайхын үйлдүүлэх хэв, лаглагар болгох.

ЛАГЛАЙХ лаглагар болох; **лаглайн суух** (а. хүний үйл ажилд хөдөлгөөн муутай байх; б. хүний дув дуугүй ихээр зан гаргаж суух).

ЛАГС хүнд чамбай; *лагс биетэй хүүхэд.*

ЛАГХИЙХ 1. хүнд юмны нүргээнтэй нүсэр унах, буух байдал; *лагхийтэл сиух; лагхийж унах;* 2. шилжээн гэнэт тулгаран учрах; *лагхийн уулзав; лагхийн тулгарав.*

ЛАГШАА I тооны нэр, арван түм буюу зуун мянга, бум ч гэдэг.

ЛАГШАА II амьтан далайд оршдог, толгой лахын толгойтой адил, хайрс байхгүй, хэвэл их, 50—60 см. урт, элэгний өнгө шаравтар **болоод энгийн загасныхаас** маш том элэгтэй нэгэн зүйл загас.

ЛАГШИМ маш нуршин, наалдамхай, унжралдсан, зунгаралдсан байдалтай юм.

ЛАГШИН биеийн хүндэтгэл, биеийн байдал; **бие лагшин** хорш.; *лагшин тунгалаг уу?* **лагшин чилүүр** (бие өвчтэй).

ЛАГШИХ 1. идээ юмны маш нуршин болох, багших; 2. хүний хэл дэвсэн нялуун алхаг ярих.

ЛАД: лад чичүү бүдүүн нэхээстэй, яс чанар муухан нэгэн зүйл чисчүү.

ЛАДУУ эрс буурцгийг няцчиж, тогтуус, бор суйхыг исгэлэн усанд найруулж хийсэн холимог идээ.

ЛАЙ I хог буртаг; *худагны лай.*

ЛАЙ II үйл зовлон; **үйл лай, лай зовлон** хорш.; **2. төвөг, яршиг;** *лай болохоор зай бол зүйр;* **бөөн лай** (яршиг төвөгтэй явдал).

ЛАЙДАА хөдлөх явахад болхи, эв дүйгүй; *лайдаа амьтан.*

ЛАЙДАХ I **худгийн** доторхи буртаг шаврыг цэвэрлэх; *худаг лайдах.*

ЛАЙДАХ II гүжирлэх, гүтгэх, гөрдөх.

ЛАЙДГАР улбагар, нүсэр байдалтай хүн.

ЛАЙДУУЛАХ 1. лайдахын үйлдүүлэх хэв; 2. лайдагдах.

ЛАЙЖ ургамал бөмбөгөн нумны бөөрөнхийн адил хэлбэртэй нэгэн зүйл жимс.

ЛАЛ нэгэн зүйл шашны нэр; *лалын шашин; лалын мөргөлтөн; лалын сум.*

ЛАЛХАЙХ алхайх, **алхгар** байдал гаргах; *лалхайн суух.*

ЛАЛХГАР алхгар.

ЛАМ шашин санваар сахисан хүн; **лам хувраг** хорш.; *хуучны лам ноёд; лам хүн; лам нарын байдал;* **даа лам** (их лам, шашны хурал номын захиргааны хэргийг эрхлэх хүний албан тушаал); **хамба лам** (шашны хурал номын үйлийг толгойлон удирдах хүн); **хар лам** (крестосын шашны лам): **лам шувуу,** лам

нугас (ангир шувуу); **лам хорхой** а м ь т а н (жижигхэн шар цоохор нэг зүйл нисдэг хорхой).

ЛАМАРХАГ ламархуу, лам шинж байдалтай.

ЛАМАРХАХ ламын шинж байдал гаргах, хэтэрхий лам зан гаргах.

ЛАМАРХУУ ламархаг, ламын маяг байдалтай.

ЛАМП янз бүрийн хийцтэй гэрэлтүүлэх буюу халаах багаж.

ЛАМПАГ ламп.

ЛАМТАН ламын хүндэтгэл; *багш ламтан; хувилгаан ламтан.*

ЛАМТАХ ламын хурлын үйлийг тэргүүлэн гүйцэтгэх.

ЛАМТУУЛАХ ламтахын үйлдүүлэх хэв.

ЛАМХАЙ лам хүний хүндэтгэл; *тэр ламхай.*

ЛАМШУУД лам шинжтэй.

ЛАН хүндийн хэмжээ, арван цэнг нэг лан гэнэ (37,3 грамм).

ЛАНГУА у р г а м а л нэгэн зүйл амтайхан гуа: **лан тахиа** а м ь т а н (тахианы төрлийн нэг зүйл шувуу, бие жижигхэн).

ЛАНГИС цогондой.

ЛАНГУУ худалдаа үйлчилгээний газрын бараа таваарыг хамгаалах хориг сав; *лангууны ард зогсох.*

ЛАНЗ 1. Энэтхэгийн нэгэн зүйл үсэг; *ланз үсэг;* 2. нэгэн зүйлийн үсэг мэт хээ; *ланз хээ.*

ЛАНТАЙЛГАХ лантайхын үйлдүүлэх хэв.

ЛАНТАЙХ лантгар болох.

ЛАНТАНЗ у р г а м а л ягаан шар цэцэгтэй, сүрхий үнэртэй, хортой зэрлэг ургамал, эмнэлэгт хэрэглэнэ.

ЛАНТГАНАХ лантгар юмны үргэлжлэн хөдлөх.

ЛАНТГАНУУЛАХ лантганахын үйлдүүлэх хэв.

ЛАНТГАР лагс том; *лантгар толгой; лантгар биетэй.*

ЛАНТУУ юм цохих, дэлдэх зэвсэг; *төмөр лантуу.*

ЛАНТУУДАХ 1. лантуугаар цохих; 2. ш и л ж с э н эрх сүрээр далайлган албадах.

ЛАНТУУДУУЛАХ 1. лантуудахын үйлдүүлэх хэв; 2. лантуудагдах.

ЛАНЦУЙ мэс заслалын хутга, хурц үзүүртэй, хоёр талдаа иртэй.

ЛАТИН нэгэн зүйл үсэг; *латин цагаан толгой;* л а т и н **галиг** (латин үсгээр бүрдсэн галиг үсэг).

ЛАТИНЧЛАХ латин үсэг болгох.

ЛАТИНЧЛУУЛАХ латинчлахын үйлдүүлэх хэв.

ЛАХ I а м ь т а н толгой хамшгар, ам их, сүүл шувтан, хайрсгүй нэгэн зүйл загас.

ЛАХ II гувчуур өөшний хоёр захад уях урт мод; *лах мод.*

ЛАХАЙХ төв байдал гаргаж алхайн суух.

ЛАХГАР бүдүүн, нүсэр, том; *лахгар том биетэй; лахгар тарган шар.*

ЛАЦ будагтай давирхай мэт наалдамхай зүйл, хайлж юм наах, битүүмжлэх мэтэд хэрэглэнэ.

ЛАЦДАХ юмыг лац тавьж битүүмжлэх; лацадсан дугтуйтай бичиг.

ЛАЦДУУЛАХ 1. лацдахын үйлдүүлэх хэв; 2. лацдагдах.

ЛЕКТОР илтгэгч, лекц бичдэг уншдаг хүн; *аймгийн намын хорооны лектор; лекторын товчоо.*

ЛЕКЦИ 1. зааж сургах, таниулах, мэдрүүлэх ямар нэг сэдвийг ярих илтгэл; *лекци унших; сонирхолтой лекци хийв;* 2. мөн ярих илтгэхэд зориулан бичсэн сэдэв; *лекцийн сэдэв; лекци бичих; лекцийн суртал нэвтрүүлэг; лекцийн тинхим.*

ЛЕНИНИЗМ 1. империализм ба пролетарийн хувьсгалын үе дахь марксизм; 2. ленинийн онол, сургаал.

ЛЕНТ 1. нарийн зурвас тууз; *гэзгээ лентээр боосон; торгон лент;* 2. ямар нэгэн зурвас нарийн зүйл; *бичгийн машины лент; киноны лент;* **тусгаарлах лент** (цахилгааны гүйдлээс хамгаалах).

ЛИБЕРАЛ 1. либерализмын талынхан; 2. либерал намын гишүүн.

ЛИБЕРАЛИЗМ хөрөнгөтний хувьсгалын үед бол аж үйлдвэрийн хөрөнгөтний эрх аш-

гийг хамгаалагч эдийн засаг улс төрийн үзэл санааны цогц, империализм ба пролетарийн хувьсгалын үед бол ажилчин анги хөдөлмөрчин олон түмний эсрэг харгис урсгал.

ЛИГ I: **лиг мод** ургамал дүм модны навчны адил навчтай, шар цэцэгтэй, бэржгэр луугийн нүд мэт цөмтэй нэгэн зүйл мод.

ЛИГ II: **лиг бөх** тэмээний унанги бөх; *зөв лиг, буруу лиг бөхтэй тэмээ.*

ЛИЙ хүнд хөнгөний хэмжээ, пунг арав хуваасны нэг буюу арван хуу (37,3 миллиграмм). •

ЛИЙР ургамал 1. саргай цэцгийн язгуурын жимсний мод, үүгээр эдлэл хэрэгсэл хийнэ; 2. мөн модноос ургадаг амтат жимс.

ЛИМ нийлмэл төмөрлөг, хүрэлтэй ойролцоо.

ЛИМБЭ үлээдэг хөгжмийн зэвсэг, дуу нарийн, гулд хэлбэртэй дотроо хөндий; *лимбийн дуу; лимбэ үлээх.*

ЛИМБЭДҮҮЛЭХ лимбэдэхийн үйлдүүлэх хэв.

ЛИМБЭДЭХ лимбээр хөгжимдөх.

ЛИМБЭЧ лимбэдэхэд чадамгай хүн.

ЛИМЖ имж.

ЛИМОН нимбэг; *лимоны шүүс.*

ЛИН нэгэн зүйлийн нимгэн торгомсог бараа.

ЛИНОТИП үсгийг өөрөө цутгаж өрдөг машина.

ЛИНС панснаас арай зузаан, дэвсгэр сайтай, нягт нэхсэн нэгэн зүйл торгомсог эд.

ЛИНСИЙ аар саар, жижиг сажиг янз бүрийн юм; *линсий бараа; линсий наймаа.*

ЛИНХУА лянхуа •

ЛИНЧДҮҮЛЭХ линчдэхийн үйлдүүлэх хэв.

ЛИНЧДЭХ инцдэх.

ЛИО мал тэжээх үр буурцгийн зэрэг юм.

ЛИОХ амьтан зэвгийн төрлийн нэгэн зүйл загас.

ЛИОХИА: **лиохиа төмс** ургамал янз алим мэт, намар болсон хойно өнгө нь шар болно, амт амтайхан болоод хүчтэйхэн, цөмөө бат нэгэн зүйл жимс.

ЛИРЛИГ амьтан янз үхэртэй адил болоод барсын бидэр мэт бидэртэй, гинших мэт дуугардаг нэгэн зүйл гөрөөс.

ЛИСЭЭ ургамал гүйлсний адил иштэй нэг зүйл жимсний мод, жимсний амт хүчтэй болоод амтайхан.

ЛИТ цаг улирлын тооны бичиг, хунли ч гэнэ; *лит хийх.*

ЛИТЕР уналга хөсгөөр үнэ төлбөргүй буюу хөнгөлттэй үнээр зорчин явах бичиг; *онгоцоор явах литер бичүүлэх.*

ЛИТР шингэн юмыг хэмжих багтаамжийн хэмжүүр, 1000^3 см., бас мөн хэмжээний шингэн зүйл; *хоёр литр сүү; литрийн лааз.*

ЛИТРЛЭХ литрээр хэмжих; *сүү литрлэх.*

ЛИШ ургамал өнгө бор, амт исгэлэнхэн бөгөөд халуувтар, хадаасан хэлбэртэй нэгэн зүйл үр, эмнэлэгт хэрэглэнэ.

ЛОВОН 1. шашны ёсонд ямар нэгэн дацан, хурал номын үйлийг эрхлэн удирдах хүний албан тушаал; 2. ямар нэгэн үйл ажлыг удирдан зааварлах багш.

ЛОВУУ амьтан ногоон доожинчтой адилхан болоод жижигхэн нэгэн зүйл бялзуухай.

ЛОВХ 1. угаасаа усархаг хөрстэй тариалан тарьж болохгүй газар; 2. хавар цас бороо хэтэрч чийг нь ихдэн тариалан тарихад тохиромжгүй болсон газар.

ЛОВШ новш, хог.

ЛОВШДОХ хэтэрхий ловш болох.

ЛОВШИРХОГ ловш ихтэй, новширхог.

ЛОВШИРХУУ ловш хог ихтэй, новширхуу.

ЛОВШРОХ новш хог их болох, новшрох.

ЛОГИКА учир шалтгааны ухаан.

ЛОГЛОГОР лохгор, бандгар бүдүүн.

ЛОГЛОЙЛГОХ логлойхын үйлдүүлэх хэв.

ЛОГЛОЙХ лохойх, логлогор болох.

ЛОГШ 1. гахайн өвс хурааж хэвтсэн газар; 2. новш хог.

ЛОГШИХ исгий бөс зэргийг хөшиж хатган бүдүүлэг оёх; *дээл логших; бамбай логших.*

ЛОГШООС логшиж оёсон оёдол.

ЛОЖ лооx.

ЛОЗУН (Г) лоозон.

ЛОЛ: лол цэцэг у р г а м а л иш ногоон, навч ногоовтор, өнгө шар, хавар цэцэглэдэг нэгэн зүйл цэцэг.

ЛОЛОЙ гахайн шагаа.

ЛОМБО 1. бараа таваарт тавих тугалган тэмдэг; 2. битүүмжилсэн лац; **ломбо лац** х о р ш..

ЛОМБОДОХ 1. юманд ломбо тавих; *шүд ломбодох;* 2. битүүмжлэх.

ЛОМБОДУУЛАХ ломбодохын үйлдүүлэх хэв.

ЛОНХ (ОН) шингэн зүйл агуулах шавар буюу шилэн сав; *архины лонх; лонхны бөглөө; шил лонх; шаазан лонх.*

ЛОНХГОР онхгор, цүрдгэр

ЛОНХЛОХ 1. шингэн юмыг лонхонд хийж савлах; *аршаан лонхлох;* 2. шингэн юм гадна талаар хөлдөх; *ус лонхлон хөлдөх*

ЛОНХЛУУЛАХ лонхлохын үйлдүүлэх хэв.

ЛОНХОЙЛГОХ лонхойхын үйлдүүлэх хэв.

ЛОНХОЙХ онхойх, донхойх, лонхгор болох.

ЛООВУУЗ хүйтэн цагт өмсөх нэгэн зүйл малгай; *үнэгэн лоовууз.*

ЛООЕЭ 1. өвөг; *лооеэ аав; лооеэгийнд очъё;* 2. ноён; *ван лооеэ; да лооеэ.*

ЛООЖ үзэгчдийн тинхим дотор байх цөөн хүний тусгай суудал; *театрын лоож.*

ЛООЗОН 1. бэлэгдэл, уриа үг; *лоозон тавих* (лоозон хашгирах); 2. мөнхүү бичсэн бэлэгдэл, уриа үг; *лоозон бичих; лоозон барих.*

ЛООЗОГНОХ лоозон тавих.

ЛООЛОЙ гахай дуудах аялга; *лоолой лоолой!*

ЛООЛЬ у р г а м а л улаан үр жимстэй таримал ургамал, хүн иднэ, мөн үр жимсий нь лооль гэнэ; *лоолийн шүүс; улаан лооль.*

ЛООМ царил.

ЛООМЬ бүгнэж хөгшилсөн тутраг амуу.

ЛОТО зурагтай буюу эсвэл дугаарласан модоор тоглох наадам; *лото тоглох.*

ЛОХГОР тарган, бүдүүн, том биетэй; *лохгор шар.*

ЛОХОЙХ лохгор болох.

ЛОШГО у р г а м а л саргай цэцгийн язгуурын өвс, үр нь малын үс хийгээд хувцсанд шивж тарна.

ЛӨӨ: лөө лөө дэмий гэсэн санаа илэрхийлэхэд хэрэглэх аялга; *лөө лөө болов; чиний модонд явах ч лөө лөө болох шив дээ.*

ЛӨӨЛГӨР өөвгөр үзэмж муутай юм; *лөөлгөр бор гэр; лөөлгөр амьтан явж байна.*

ЛӨӨЛИЙХ лөөлгөр болох.

ЛӨТНӨ будний ангаахай.

ЛУГ: луг луг хийх 1. түг түг хийх: *зүрх луг луг хийх;* 2. луг луг хийх; *судас луг луг хийх;* 3. чинэрч өвдөх; *гарын хавдар луг луг хийн өвдөж зовоогоод байна.*

ЛУГАА б и ч и г э р үгийн хамтрахын тийн ялгаллын дагавар: тай; **аав лугаа** (аавтай).

ЛУГЛАГАР маш тарган бүдүүн; *луглагар шар; луглагар том хүн.*

ЛУГЛАЙЛГАХ луглайхын үйлдүүлэх хэв.

ЛУГЛАЙХ луглагар болох.

ЛУГШИХ 1. битүү цохилон хөдлөх; *судас лугших;* 2. чинэрч өвдөх; *хавдсан газар лугшин өвдөж байна.*

ЛУГШУУЛАХ лугшихын үйлдүүлэх хэв.

ЛУЖИГНАХ нужигнах, бужигнах.

ЛУЖИГНУУЛАХ лужигнахын үйлдүүлэх хэв.

ЛУЙВАР гөр, гүжир; *луйврын юм; луйвраар явах.*

ЛУЙВАРДАХ 1. бусдын юмыг гүжирлэн, мэхлэн, булааж авах; *чи битгий луйвардаад бай! улаан цайн луйвардав;* 2. булхайцах, булхайлах.

ЛУЙВАРДУУЛАХ 1. луйвардахын үйлдүүлэх хэв; 2. луйвардагдах.

ЛУЙВАРЧИН бусдын юмыг гүжирлэн булааж авагч; *өдрийн луйварчин; улаан цайн луйварчин.*

ЛУЙЛ у р г а м а л үхсэн газар ургадаг нэг зүйл ургамал; *хашааны луйл хадах; луйл зулгаах.*

ЛУС 1. буддын шашны ёсны газар усанд оршигч хүн бусын амьтан; *лусын хаан;* **савдаг лус** х о р ш.; 2. найман тооны ёгт нэр.

ЛУТ I том, сүрхий, мундаг; *лут байшин болжээ; лут эр; лут хэрэг.*

ЛУТ II нээхгүйгээр хийсэн цонх.

ЛУТ III бат; **лут бат** х о р ш.; *лут суурьтай; энэ ч харин лут бөх гутал байна даа.*

ЛУУ I 1. эрт цагийн аврага гүрвэлийн нэр; *лууны яс;* 2. шар цагаан зурхайн ёсны арван хоёр жилийн тавдугаар; *луу жил; луу өдөр;* 3. хаврын сүүл сар; *луу сар;* 4. өдөр бүрийн өглөөний 7—9 цаг; *луу цаг.*

ЛУУ II үлгэрийн амьтан; ☆ **лууны нүд** у р г а м а л (модонд ургадаг, хавар зуны завсраар цэцэглэдэг, бяцхан цагаан цэцэгтэй, намар жимс нь хонгорцоглон ургадаг, моголцог бөмбөг мэт хэлбэртэй, хатуу хальстай, амт амтайхан нэгэн зүйл жимс); **лууны нүдлэг** у р г а м а л (модны навч нь лууны нүд ба лууны нүдний навчтай адил нэгэн зүйл жимс, жигнэж иднэ, түүхий идэж болохгүй); **луут хүжин мод** у р г а м а л (дүгрэг навчтай, цэцэг үр байхгүй, маш өндөр, шүүс ихтэй нэгэн зүйл мод); **луун хээ** (лууны дүрсийг гаргасан хээ; *луун хээтэй торго).*

ЛУУВАН у р г а м а л хүн иддэг гашуувтар амт бүхий үндэстэй таримал ургамал, **гашуун лууван** у р г а м а л; (малын тэжээлийн цагаан луувангийн нэгэн өөр маяг); **улаан лууван ургамал** (хүн иддэг цагаан буюу улаавтар үндэстэй таримал ургамал); **цагаан лууван** у р г а м а л (бөөрөнхийвтөр бүдүүн үндэстэй идэшний ногоо; т э ж э э л и й н ц а г а а н л у у в а н): **шар лууван** у р г а м а л (бүдүүвтэр улбар шар, амтлаг үндэстэй идэшний ногоо).

ЛУУЖИН зүг олох багаж компас.

ЛУУЛЬ у р г а м а л 1. жижигхэн дүгрэг навчтай, улаавтархан иштэй ногоо, борлуулж иддэг, төрөл зүйл олон; *хурган лууль; хонин лууль; морин лууль;* 2 .янз байдал лууль тай адил нэгэн зүйл өвс; *лууль өвс;* 3. тариалангийн ургацад хохирол учруулах нэгэн зүйлийн шарилж.

ЛУУС илжиг гүү хоёрын дундаас төрсөн эрлийз адуу.

ЛУУХ нуух; *нүднээс луух гараад байна.*

ЛУУХТАХ нуухтах.

ЛУХАЙЛГАХ лухайхын үйлдүүлэх хэв.

ЛУХАЙХ лухгар болох.

ЛУХАН: лухан жимс у р г а м а л янз байдал нанхиад арурийн адил болоод олон давхар арьс хальстай нэгэн зүйл жимс.

ЛУХГАР бие бараа том тарган юм; *лухгар тарган шар.*

ЛҮВХИЙХ халуун салхи үе үе салхилах; *салхи лүвхийн үлээв.*

ЛҮВЧ өвч.

ЛҮВЧЛЭХ өвчлөх.

ЛҮГ: лүг лүг хийх байн байн лугших; **лүг хийм халуун** (салхигүй бөгчим их халуун).

ЛҮГЛИЙХ лүглэгэр болох.

ЛҮГЛЭГЭР элбэг том, лухгар; *лүглэгэр дээл; лүглэгэр том биетэй хүн.*

ЛҮГХИЙХ 1. хүнд юмны унахад гарах чимээ; *лүгхийтэл унах чимээ гарав; зүрх лүгхийж байв;* 2. бөгчим халуун болох.

ЛҮГЧИН у р г а м а л үнэргүй том цэцэгтэй нэг зүйл ургамал, цэцгийн өнгө олон янз.

ЛҮД ш а ш и н золиос, золио болгох гурилаар хийсэн хүний дүрс.

ЛҮЖИГНЭХ нүжигнэх; *тэнгэр лүжигнэх.*

ЛҮЖИСГЭЛЭН: лүжисгэлэн цэцэг у р г а м а л иш навч уулын цайны цэцгийн адил, тоорцог том, их үнэртэй нэг зүйл цэцэг.

ЛҮНДЭН х у у ч и р с а н зарлиг, эш, бошиг; **зарлиг лүндэн, эш лүндэн, бошиг лүндэн** х о р ш.,

ЛҮНТЭН нэг зүйл ургамлын үр.

ЛҮҮ цуудас туйванг сүлжин цаас давхарлан хулдаж хийсэн сав; *тосны лүү; лүүтэй айраг;* **лүү хөнөг** (шингэн зүйл агуулах том сав); **архины лүү** ш и л ж с э н (архи их уудаг хүн); **хогны лүү** ш и л ж с э н (юм бүхнийг шингээгч, идэгч).

ЛХААРАМБА Төвдийн Лхас хийдэд дамжаа барьсан гавж.

ЛХАГВА долоон гаргийн гуравдугаар Буд гариг; *Лхагвад хичээл эхэлнэ.*

ЛЭГ: лэг бөх тэмээний дээш босохгүй хажуу тийш налж унасан бөх; *лэг бөхтэй тэмээ.*

ЛЭГЛИЙЛГЭХ лэглийхийн үйлдүүлэх хэв, лэглэгэр болгох.

ЛЭГЛИЙХ лэглэгэр болох.

ЛЭГЛЭГЭР ус ихтэй, зузаан, бүдүүн; *лэглэгэр малгай; лэглэгэр дээл; лэглэгэр нохой.*

ЛЭНСИЙ аар саар, жижиг сажиг эд юм; *лэнсий бараа; лэнсий наймаа.*

ЛЭНТГЭР лантгар.

ЛЭНТИЙХ лантайх.

ЛЮСТРА цэцгэн дэн. 2

ЛЯНГА: лянга хоног амуу хоног амуутай адил болоод өчіө нь цэгээн, идэхэд илбэрүү тааламжтай нэгэн зүйл будаа.

ЛЯНХУА у р г а м а л удвалын аймаг, усанд ургана, шудрага иштэй, том сайхан цэцэгтэй, дүгрэг навчтай, сайхан үнэртэй цэцэг; *лянхуа цэцэг;* **цагаан лянхуа** (цэцэг цагаан); **улаан лянхуа** (цэцэг улаан); **лянхуа цанхуй** у р г а м а л (цанхуй цэцгийн нам, хэд хэдэн давхарга хэлтэстэй, чиз байдал лянхуа цэцэгтэй адил); **лянхуа цэцгийн хонгорцог** (лянхуа цэцгийн гол, цэцэг нь зулгарсны дараа ургадаг буурцгийн нэр); **лянхуа цэцгийн үр** (лянхуа цэцгийн буурцгийн дотоод цөмийн идээ): **лянхуа цэцгийн оо, лянхуагийн оо** (лянхуа цэцгийн үндсийг устай хольж тээрэмдэн, усыг шүүрүүлэн хагсааж үлсэн гурил мэт нунтаг, үүнийг чихэртэй усаар зуурч унд болгон хэрэглэнэ). 2

М

М монголын цагаан толгойн үсэг, М үсэг. М авиа. -ф-

МА гартаа барьж байсан юмыг бусдад өгөхдөө өгүүлэх аялга; *ма, чи үүнийг ав!* -ф!

МАА ма, май гэж хэлэх аялга.

МААВУУЗ лоовууз.

МААДАЙЛГАХ 1. маадайхын үйлдүүлэх хэв; 2. маадгар байдал гаргах.

МААДАЙХ маадгар болох.

МААДАЛЗАХ маадгар юмны байн байн хөдлөх.

МААДГАНАХ маадгар юмны үргэлжлэн хөдлөх.

МААДГАР санаа сэтгэл ханамжтай зохистой байдал илэрхий байгаа юм; *миний хүү хөхөө хөхчихөөд маадгар хэвтэнэ.*

МААЖИН будаг зуурах, ширдсэн юмыг өнгөлөх тос, маалинга буюу олсны тосоор хийнэ; *шар маажин; маажинтай даавуу.*

МААЖИНДАХ юманд маажин түрхэж өнгөлөх.

МААЖИНДУУЛАХ маажиндахын үйлдүүлэх хэв.

МААЖИХ 1. үтрэх, шүргэх, үрэх; *загатнасан газрыг маажих; хумсаар маажих; зулга маажих;* **хорыг маажих** (хорыг хөдөлгөх, тачаадуулах); 2. самардах, зурчих; *муур маажиж орхив.*

МААЖЛАХ байн байн маажих; *нохой газар маажлав.*

МААЖУУЛАХ маажлахын үйлдүүлэх хэв.

МААЖУУЛАХ маажихын үйлдүүлэх хэв.

МААЖУУР I арьсны нэгэн зүйл өвчин, загатнуур ч гэнэ; *над маажуур тусаад загатнаад байна.*

МААЖУУР II маажих зэвсэг; *хулсан маажуур; морины маажуур; өвсний маажуур.*

МААЖУУР III гурилаар маш жижиг хийсэн нэгэн зүйл идээ; *маажуур боов.*

МААЖУУРТАХ маажуур өвчин тусах.

МААЗ марзан, сагсуу, ёргио; *мааз хүн;* маазай ч гэдэг.

МААЗАЙЛГАХ маазайхын үйлдүүлэх хэв, маазгар байдал гаргах.

МААЗАЙХ маазгар болох.

МААЗАЛЗАХ маазгар юмны байн байн хөдлөх.

МААЗГАНАХ маазгар юмны үргэлжлэн хөдлөх.

МААЗГАР зан байдал сууригүй маягтай.

МААЗРАХ мааз зан байдал гаргах, хэвийн байдал нь алдарч сонирхол буурах; *ажил маазарч орхив.*

МААЗРУУЛАХ маазрахын үйлдүүлэх хэв.

МААЛИНГА I у р г а м а л утас хийх ба тос гарган авах өвсөрхөг ургамал; *маалинган нэхмэл; малингын тос.*

МААЛИНГА II олс хялгасаар нэхсэн том шуудай; *маалинган шуудай.*

МААЛИНГА III ичих зовохыг мэдэхгүй заваан бүдүүлэг яриатай хүн; *маалинга амьтан.*

МААЛИНГАРАХ маалинга зан байдал гаргах.

МААЛУУ жижгэвтэр лүү; *маалуутай архи.*

МААМ маамаа.

МААМАА 1. зарим газар эх эгч хүмүүсээ үр хүүхэд нь ийнхүү нэрлэнэ; 2. маам.

МААМГАНАХ хэвийн биш байдал гаргасан хүнийг шоодворлон ийнхүү өгүүлнэ; *битгий маамганаад бай!*

МААМУУ хүүхдийг өхөөрдөн нэрлэх нэр; *маамуу нааш ир, манайд очиж тоглоё* (дуу).

МААНАГ эргүү, тэнэг, дүйнгэ, мунхаг; *маанаг гайхал.*

МААНАГАР дүйнгэ донгио байдалтай.

МААНАГЛАХ маанаг байдал гаргах, тэнэглэх, дүйнгэдэх.

МААНАГРАХ маанаг болох, тэнэгрэх, дүйнгэрэх.

МААНАГТАХ маанаг зан гаргах, эргүүтэх, дүйнгэтэх.

МААНАЙЛГАХ маанагар байдал гаргах.

МААНАЙХ маанагар болох.

МААНЬ I хамаадуулах үг; *эгч маань; айлчилж ирсэн хүн маань; өнөөх тогтсон хэлэлцээ маань; хонь маань тэнд билчиж байна; хот маань сайхан болж байна.*

МААНЬ II буддын шашны ёсны нэгэн зүйл уншлагын ном; *маань унших.*

МААПААН будлиан, самуурал.

МААПААНТАХ маапаан гаргах.

МААР утаст хөгжмийн тэвх.

МААРАЙХ мааргар болох.

МААРАЛ нэгэн зүйл нимгэн сиймхий даавуу.

МААРАМБА төвд эмнэлгийн арга ухаанд мэрэгжсэн хүнд олгох мяндаг.

МААРАХ хэрэг зориггүй дэмий сул байх.

МААРУУЛАХ маарахын үйлдүүлэх хэв.

МААРГАР залхууч, аанай байдалтай; *маргар амьтан даа, тэр чинь.*

МААРШИХ илэг бээж илжрэх; *илэг марших.*

МААСАЙХ маасгар болох.

МААСАЛЗАХ маасгар юмны байн байн хөдлөх.

МААСГАНАХ маасгар юмны үргэлжлэн хөдлөх; *хүүхэнтэй маасганах.*

МААСГАНУУЛАХ маасганахын үйлдүүлэх хэв.

МААСГАР марзан зан байдалтай, маадгар.

МААТАН үр тариаг ялзалж нуршин болгож хийсэн бохь мэт наалданги чихэрлэг идээ.

МААХАЙ I шаахай; хилэн маахай.

МААХАЙ II 1 нас гүйцсэн бие том эр баавгай; *шар маахай;* 2. маш том хөл; *маахай хөлтэй хүн.*

МААХАЙЦАХ шагаа наадахад урьд харвасан сумны оносон газар, хойно харвасан сум оновол газрыг сунгаж дахин харвуулах.

МААХУУР мушгимал хэлбэртэй нэгэн зүйл боов, гол төлөв үрийн тосонд чанана.

МААЮУЗ эмээлийн дээр давхцаж хэрэглэх бяцхан дэвсгэр.

МААЮУЗЛАХ эмээл дээр юм давхацлан тохох; *цуваа мааюузлав.*

МААЮУР нэгэн зүйл нарийн боов, гол төлөв үрийн тосонд чанана.

МАГАД 1. лав, гарцаагүй, үнэн; *чи магад мөн; би ч магад явна; магад, үнэний хувьтай; үнэн магадыг олох; малгайн нь орой адилхан байна, магад хүү минь ирэв үү дээ* (Учиртай гурван толгойгоос); 2. болзошгүй, *магадгүй; Мандах нэгдэл л төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн байж магад;* ☆ **магад гарах** (шашны ёсонд гэлэн санваар сахиж тойн болох; *гэрээс магад гарах);* **магад гарахын тэмдэг** х у у ч и р с а н (а. лам болоход албан газраас өгсөн тэмдэгт бичиг; б. гэрээс гарсны тэмдэг болох хувцас хунарын зүйл).

МАГАДГҮЙ болзошгүй, лавтай биш, итгэлгүй; *би маргааш ирж ч магадгүй; тэр чинь яаж ч магадгүй хүн шүү.*

МАГАДЛАГДАХ магадлахын үйлдэгдэх хэв.

МАГАДЛАХ 1. юмны үнэн ташааг хянаж тодорхойлох; *магадлан хянах; үнэн худлыг магадлах; зөв бурууг магадлах;* 2. тодорхой тогтоох, илрүүлэх, мэдэх; *өнцгийг магадлах* (бодож гаргах); *зайг магадлах; магадлан үзэх;* **магадлах үнэн** (баталгаа шаардагдах зүйл).

МАГАДЛАШГҮЙ магадлаж болшгүй, санамсаргүй, болзошгүй; *магадлашгүй зардал; магадлашгүй хэрэг гарав.*

МАГАДЛУУЛАХ 1. магадлахын үйлдүүлэх хэв; 2. магадлагдах.

МАГАДЛУУШТАЙ магадлавал зохилтой.

МАГНАГ луу хээтэй, алт мөнгөн утас оруулан нэхсэн торго; *магнаг дээл; магнаг үсэгтэй тугийгаа, магнай дээрээ мандуулав* (ардын дуу).

МАГНАЙ 1. толгойн өмнөд, нүүрийн дээд хэсэг; *өргөн магнайтай; магнай атируулах; магнай дээрээ цагаан сартай; хүн хэдий баярлавч, магнай үл хагарах хууч;* **магнай тэнийх** (үлэмж баярлах); **магнай авах** (магнай дээр няслах, цохдох); 2. тэргүүн, толгой; **бөхийн магнай** (хамгийн тэргүүнд гарах бөх): *баярын магнай, бат идэр хүлэг* (хурдан морины цол).

МАГНАЙВЧ 1. магнайн чимэг; *сувд магнайвч;* 2. дуулганы магнайд хадсан янз төмөр.

МАГНАЙДАХ 1. магнай дээрээс барих, тулах, магнайд хүрэх; 2. шилжсэн магнайлах; *хүрэн морь магнайджээ.*

МАГНАЙЛАХ 1. тэргүүлэх, тэргүүн зэрэгт орох; 2. магнай бөх болох.

МАГНАЙТАХ магнай болох, магнайлах.

МАГТААЛ 1. юмны сайн сайхныг сайшаан өгүүлсэн зүйл; **магтаал сайшаал хорш.**; *Богд уулын магтаал; морины магтаал;* 2. утга зохиолд ямар нэгэн түүхт явдал буюу баатарт зориулсан баясгалант шүлэг.

МАГТААЛЧ магтаал хэлдэг хүн; **ерөөлч магтаалч хорш..**

МАГТАГДАХ магтахын үйлдэгдэх хэв, сайшаагдах.

МАГТАХ сайшаах, сайны нь гарган хэлэх; *магтан дуулах; морио магтах; биеэ магтах;* **ах орноо магтах;**

МАГТЛАГА магтах үйлийн нэр; *магтлага ихэдвэл тусгүй; хоосон магтлага хор болдог.*

МАГТУУ дэлгэрүүлэн өргөж магтсан үг ба зохиол; *магтуу дуу; магтуу үг.*

МАГТУУЛАХ 1. магтахын үйлдүүлэх хэв; 2. магтагдах.

МАД 1. шатраар тоглоход ноёныг нүүх нүүдэлгүй болгох хожил; *мад хийх; хэд нүүгээд мад цохив;* 2. хэлэлцэхэд хэлэх үггүй болгох; *мад тавих.*

МАДАГ ташаа, алдаа; **алдаа мадаг хорш.**; *мадагтай бичиг; мадгий нь зас!*

МАДАГГҮЙ 1. алдаагүй, зөв; 2. магад үнэн, осолгүй, итгэлтэй, найдвартай.

МАДАГЛАХ юмны алдааг хянаж мадгий нь гарган үзэж засах, шүүдэглэх.

МАДАГТАЙ 1. алдаатай, дутагдалтай; *мадагтай бичжээ;* 2. итгэлгүй, осолтой, найдваргүй.

МАДАЙЛГАХ мадайхын үйлдүүлэх хэв, мадгар болох.

МАДАЙХ мадгар болох.

МАДАЛ: мадал **аяга** асар том аяга.

МАДГАР 1. хэвлүүн, пидгэр; *мадгар хүүхэд* 2. бахим пандгар; *мадгар хурга.*

МАДЛАХ 1. шатраар тоглож мад хийх; 2. бусдыг үгээр мохоон давж мад тавих.

МАДЛАГДАХ мадлахын үйлдэгдэх хэв, мадлуулах.

МАДЛУУЛАХ 1. мадлахын үйлдүүлэх хэв; 2. мадлагдах.

МАЖИЙЛГАХ мажийхын үйлдүүлэх хэв.

МАЖИЙХ үхэх, нөгчих; *манай муу эргүү хурга мажийжээ.*

МАЙ I басгасан их утаа; *ялаа шумуулыг үргээхээр аргал шатааж май тавив.*

МАЙ II юмыг бусдад өгөхөд хэрэглэх аялга; *май, чи ав; май үүнийг ахдаа хүргэж өгөөрэй.*

МАЙ III аргын улирлын тавдугаар сар; *Майн нэгний баяр.*

МАЙ IV: **май загас** амьтан далайн усанд орших нэг зүйл жижиг загас, махы нь давсалж иднэ.

МАЙГА амьтны хөл шилбэ хэвийн биш байдалтай; *гадагш майга; дотогш майга; майга; хөлтэй хүүхэд.*

МАЙДАХ юмыг майгаар утах; *тарваганы нүх майдах.*

МАЙДУУЛАХ майдахын үйлдүүлэх хэв.

МАЙЖГАНАХ майжиг юмны үргэлжлэн хөдлөх; майжиг майжиг явах.

МАЙЖГАНУУЛАХ майжганахын үйлдүүлэх хэв.

МАЙЖГАР майжгий юм.

МАЙЖГИЙ майжиг, майжгар.

МАЙЖИГ хэвийн байдлаас хажуу тийш муруй болсон нь; *майжиг гутал; майжиг гишгэх.*

МАЙЖИЙЛГАХ майжийхын үйлдүүлэх хэв, майжиг болгох.

МАЙЖИЙХ майжиг болох, хажуу тийш хазайх; муруйх; *гутал майжийх.*

МАЙЖИЛЗАХ майжгар юмны байн байн хөдлөх; майжис майжис хийх.

МАЙЖИЛЗУУЛАХ майжилзахын үйлдүүлэх хэв.

МАЙЛААН: уйлаан майлаан уйлаан шуугиан; *уйлаан майлаан болох.*

МАЙЛААС у р г а м а л нарстай адил болоод хавтгай шилмүүстэй нэгэн зүйл мод.

МАЙЛАХ хонь ямааны дуудан дуугарах; *майлсаар майлсаар мал болдог, уйлсаар уйлсаар хүн болдог* з ү й р.

МАЙЛС у р г а м а л хайрс давхаргатай мэт жижиг, халуун оронд ургадаг мөнх ногоон, шилмүүст мод.

МАЙЛУУЛАХ майлахын үйлдүүлэх хэв.

МАЙЛЦ у р г а м а л зэгсний навчтай адил навчтай нэгэн зүйл өвс, үндсийг авч хэрэглэх нь бий.

МАЙМАА худалдаа, наймаа; **маймаа худалдаа, наймаа арилжаа** х о р ш.;

МАЙМААЛАХ арилжин худалдаалах, наймаалах; *морио маймаалах; ташууpаа маймаалах.*

МАЙМАЙХ маймгар болох.

МАЙМАР: маймар маймар хийх 1. нялх хүүхэд буюу хөгшин хүмүүсийн юм идэх; *маймар маймар зажлах;* 2. хөл муутай хүмүүсийн дэм муутай хөдлөх; *маймар маймар гишгэх.*

МАЙМГАР шүд нь унаж уруул нь шамбигар болсон нь; *маймгар амтай.*

МАЙМРАХ 1. мижилзэх, сүйтэлзэх, хазганах; 2. ш и л ж с э н шүдгүй хүний юм идэх.

МАЙМРУУЛАХ маймрахын үйлдүүлэх хэв.

МАЙРАГ хөгширч шүд нь унасан нь; майрдаг ч гэнэ.

МАЙРАГЛАХ майраг болох.

МАЙРАХ 1. хүний шүд унаж ам уруул нь хэвийн байдлаас аягүй болох; 2. хөгшрөх.

МАЙРГА: майрга майрга хийх майргар хөлтэй хүний явах байдал.

МАЙРГАНАХ майргар юмны майрга майрга хийж явах.

МАЙРГАНУУЛАХ майрганахын үйлдүүлэх хэв.

МАЙРГАР том хөлтэй.

МАЙРДАГ 1. шүд унасан, хөгширсөн нь; *майрдаг эмгэн;* 2. ш и л ж с э н ир нь мохсон нь; *майрдаг хутга.*

МАЙРИЙХ майргар болох.

МАЙТАЛЗАХ майтгар юмны майтас майтас хийх.

МАЙТГАНАХ майтгар юмны майтга майтга хийх.

МАЙТГАР хүн амьтны хөл тойдгор; **майтгар тойдгор** х о р ш..

МАЙТИЙХ майтгар болох.

МАЙХАН бөс даавуугаар хийсэн, модон багана нуруутай оромж; хэлбэр байдал нь янз бүр байдаг; **майхан шаах, майхан татах** (майхан барих); **майхны ам** (үүд): **майхны ваадан** (майхны ам талыг нээх зөрүүлэх хоёр хушуу); **майхны нуруу** (хоёр баганын дээд үзүүр дахь сэнжинд тогтоох урт мод); **майхны шувуу** (майхны багана); **майхны гол** (майхны их биеийн хоёр талын хэц); **майхны самсаа** (майхны шанааны хойд урд хоёр хэц); **майхны сүүл** (майхны бөгсөн этгээдийн нарийн үзүүр); **майхны хаяавч** (майхны хаяа тойрон хийсэн унжлага бөс); **майхны хэц** (майхны олон уулзарт бэхлэн хийсэн олс дээс); **майхны шанаа** (майхны хоёр голын хойд урд хоёр хушуу).

МАЙХУА у р г а м а л иш богино, хөндлөн тийш тохойлон ургасан ац салаатай, найлзуурын дурс ногоон, навч гүйлсний навчтай адил болоод үзүүр шуумгай, цэцэг нь таван хэлтэстэй, сайхан үнэртэй, аливаа цэцэгнээс урьд цэцэглэдэг нэгэн зүйл цэцэг.

МАЛ 1. хөдөө аж ахуйн дөрвөн хөлт амьтан адгуус; **хонь мал, адуу мал** х о р ш.; **мал сүрэг; таван хошуу мал** (хонь, ямаа, үхэр, адуу, тэмээ): **нийгмийн мал** (нэгдэлд нийгэмчилсэн мал; *нийгмийн малыг өөрийн мал шиг харцуулах хэрэгтэй);* **амины мал** (нийгэмчлээгүй хувьд үлдсэн мал); **бод мал** (адуу, үхэр тэмээ); **бог мал** (хонь ямаа); **богино хөлийн мал** (хонь ямаа); **халуун хошуутай мал** (хонь, адуу); **хүйтэн хошуутай мал** (тэмээ, ямаа, үхэр); **малын хашаа** (малыг хүйтнээс болон ийш тийш явахаас хамгаалан барьсан барилга); **мал төллөх** (малын үр зулзагаа гаргах); **мал оторлох** (малыг авч билчээртэй газар дагуулан алсхан гаргаж маллах); **мал тэвээрэх** (муудсан мал сайжирч эхлэх); **мал маллагаа** (мал адуулах арга ажиллагаа); **малын тоолого** (малын тоог гаргах): *малын тооллогын комисс);* **малын тэжээл** (хадсан өвс, дарш зэрэг малд бэлтгэсэн идэш); **малын бэлчээр** (мал идэшлэх газар); *малын бэлчээрийг сайн ашиглах);* **мал бааз** (улсын бэлтгэлийн малыг хүлээн авах суурь): **мал туувар** (улсын бэлтгэлийн малыг хүлээн авах баазад хүргэхээр тууварлан явах); **мал туугч** (улсын бэлтгэлийн мал тууварлан явагч); **малын ашиг шим** (малын үс ноос, арьс шир, сүү, мах тэргүүтэн бүхий л ашигтай зүйлс; *малын ашиг шимийг нэмэгдүүлэх);* **мал эмнэлгийн ухаан** (малын өвчин, түүнийг эмчлэн засах тухай ухаан); **малын эмч** (мал эмнэлгийн ухаанд мэрэгжсэн хүн); **мал эмнэлэг** (малын өвчин эмгэгийг сэргийлэх эмчлэх газар; *сумын мал эмнэлэг дээр очоод ирлээ);* **мал нядлах** (мал алах); **малын зах** (мал худалдаалах газар); **мал аж ахуй** (малын ажил эрхэлсэн аж ахуй); **мал тариалангийн ажил** (мал ба тариалан хосолсон ажил); **мал бригад** (малын ажлыг эрхэлсэн бригад); **мал малын захтай** (таван хошуу малын аль алинаас ч цөөн тоотой байгаа); *мал гэвэл хойшоо, мах гэвэл урагшаа* з ү й р; *мал эзнээ дууриадаг, малгай толгойгоо дууриадаг* з ү й р; *мал муугаа сэжнэ, малгай толгойгоо дарна* з ү й р.

МАЛАР амьтан мануулын нэгэн зүйл.

МАЛАРХАГ 1. мал ихтэй; *малархаг айл, малархаг нэгдэл;* 2. малч, малд сайн; *малархаг хүн.*

МАЛАРХУУ малархаг.

МАЛГАЙ толгойд өмсөх хувцас, хэлбэр дүр олон янз; *сийрсэн малгай; үнэгэн малгай; өвлийн малгай; малгайн орой; малгайн сагалдарга;* **малгай авбал манайх** (хаа очвол тэр манай гэр): **цаасан малгай өмсгөх** (хөөрүүлэх, онгирогох); ☆ **хадаасны малгай** (хадаасны товруу тав).

МАЛГАЙЛАХ цас лавс ширхгээр орох; *цас малгайлах.*

МАЛГАЙТ малгай бүхий; **малгайт хадаас** (том товруу тавтай хадаас).

МАЛГАЙЧ (ИН) малгай хийдэг хүн.

МАЛЖИХ малтай болох.

МАЛЖУУЛАХ малжихын үйлдүүлэх хэв, малтай болгох.

МАЛЗАН ихээхэн халзан; **халзан малзан** х о р ш..

МАЛИА ташуур.

МАЛИГА у р г а м а л уяхан иштэй, олон салаатай, цайны навч шиг навчтай, цагаан өнгөтэй, хүйс нь бяцхан, үнэр сайхан, удшийн хирд цэцэглэх нэгэн зүйл цэцэг.

МАЛИГАНАХ малигар юмны үргэлжлэн хөдлөх, малига малига хийх; *малийсан сайхан хүүхэд байна.*

МАЛИГАНУУЛАХ малиганахын үйлдүүлэх хэв.

МАЛИГАР нүүр царай өргөн, тарган махлаг; *малигар царайтай.*

МАЛИЙХ малигар болох; *малийтал тргалах.*

МАЛИЛЗАХ малигар юмны мальс мальс хийх; *баясан сайн ааш гаргаж малилзах.*

МАЛИЛЗУУЛАХ малилзахын үйлдүүлэх хэв.

МАЛЛАГДАХ маллахын үйлдэгдэх хэв, маллуулах.

МАЛЛАХ 1. мал адуулах, хариулах; *миний эгч дүү нар хөдөө мал маллаж суудаг* 2. хүнийг асран хүмүүжүүлэх; *хүүхэд маллах;* 3. **ш и л ж с э н** мэхлэх, залилах; *маллаад хуурамч мөнгө өгчихсөн байлаа.*

МАЛЛУУЛАХ 1. маллахын үйлдүүлэх хэв; 2. маллагдах.

МАЛТААС ухлаадас; *дээлийн малтаас.*

МАЛТАГДАХ малтахын үйлдэгдэх хэв; **малтагдах амьтад** (газар дороос гарах эртний галбын үеийн амьтад); **малтагдах ургамал** (газар дороос гарах эртний галбын үеийн ургамал);

МАЛТАГДАХУУН газраас эрэн авч хэрэглэх ашигт малтмалын зүйл.

МАЛТАГЧ малтах үүрэг бүхий хүн; *ууранхайн малтагч.*

МАЛТАХ I 1. эрэх, ухах; *худаг малтах; нүх малтах ;хойшоо сууж, доошоо малтсан* з ү й р; 2. хамах, цуглуулах; *цас малтах; өтөг малтах; малтууpаар малтах;* 3. ш и л ж с э н оролдох, ухчилах; *хоры нь малтах; гэмийн уурхайгий нь малтаж олох.* -ᠮᠠᠯᠲᠠᠬᠤ

МАЛТАХ II мал шиг тэнэг зан байдал гаргах. -ᠮᠠᠯᠲᠠᠬᠤ

МАЛТАЦ I малтаж гаргасан юм. -ᠮᠠᠯᠲᠠᠴᠠ

МАЛТАЦ II цанаар явахад барих тулгуур таяг.

МАЛТМАЛ малтаж авсан юм; *ашигт малтмал.* -ᠮᠠᠯᠲᠮᠠᠯ

МАЛТУУЛАХ 1. малтахын үйлдүүлэх хэв; 2. малтагдах. -ᠮᠠᠯᠲᠤᠤᠯᠠᠬᠤ

МАЛТУУР юмыг хамж цуглуулахад хэрэглэх зэвсэг; *модон малтуур; төмөр малтуур.* -ᠮᠠᠯᠲᠤᠤᠷ

МАЛТУУРДАХ юмыг малтуураар хамах, цуглуулах. -ᠮᠠᠯᠲᠤᠤᠷᠳᠠᠬᠤ

МАЛТУУШ I малтагдах юм. -ᠮᠠᠯᠲᠤᠤᠰ

МАЛТУУШ II өвс шарилжны үндэс; *малтууш мөөг* у р г а м а л (газар дор ургадаг нэг зүйл мөөг, хүн иднэ).

МАЛТУУШЛАХ шарилж өвсний үр, намар үндэслэх; *өвс малтуушилж байна.* -ᠮᠠᠯᠲᠤᠤᠰᠢᠯᠵᠤ

МАЛУУР мануул. -ᠮᠠᠯᠤᠤᠷ

МАЛУУХАЙ а м ь т а н гахайтай адил бөгөөд нохойн хуцах адил дуутай нэгэн зүйл гөрөөс. -ᠮᠠᠯᠤᠤᠬᠠᠢ

МАЛЧ мал адуулахдаа чадамгай, сайн, дадлагатай; *малч хүн.* -ᠮᠠᠯᠴᠢ

МАЛЧИН мал сайн малладаг; *сайн малчин; малчны туршлага; сайн малчны зөвлөлгөөн.* -ᠮᠠᠯᠴᠢᠨ

МАМ шашны ёсны эм шумнас. ᠮᠠᠮ

МАМУУНА а м ь т а н молтогчин туулайтай адил төстэй, бараан өнгөтэй амьтан. ᠮᠠᠮᠤᠤᠨ

МАН бидэн; *манд; маныг; манаас; мантай.* ᠮᠠᠨ

МАНА I: **ана мана** ач тач, тэнцүү: *ана мана булаалдаж байна.* ᠮᠠᠨ

МАНА II ойр байгаа юмыг зааж хэлэлцэхэд энэ биш уу, тэр биш үү гэсэн утгаар хэрэглэх аялга; *бидний урьд хэлэлцсэн үг мана таарч нийлэлцээ биз.*

МАНА (Н) III болрын төрөлд багтах үнэт чулууны нэр, өнгө зүйл бүр; *халтар мана; цахиур мана; утаат мана; пиур мана; манан хөвөрөг.* ᠮᠠᠨᠤ

МАНА IV у р г а м а л сондуутай иштэй, хүрэн тоорцогтой, хэлтэс нь шар улаан цагаан гурван зүйл байдаг, хавар эрт цэцэглэдэг, анхилам сайхан үнэртэй; цэцгий нь манын цэцэг, сондуугий нь мана гэж нэрлэдэг, эмнэлэгт хэрэглэнэ.

МАНАА I манаач, юмыг харгалзан сахих хүн; *манаа хүлээ; үүдний манаа; манаа манах; эх орны манаа; манаа халалцах.* ᠮᠠᠨᠠᠠ

МАНАА II манаадас, манаас.

МАНААДАС манасан юм; *хаяаны манаадас.* ᠮᠠᠨᠠᠠᠳᠠᠰ

МАНААС манасан, дарж хучсан юм; *гэрийн хаяаны манаас; галын манаас; манаасны шороо.* ᠮᠠᠨᠠᠠᠰ

МАНААЧ юмыг харгалзан сахих хүн; *үйлдвэрийн газрын манаач; дэлгүүрийн манаач.* ᠮᠠᠨᠠᠠᠴ

МАНАГААР маргааш. ᠮᠠᠨᠠᠭᠠᠷ

МАНАЙ тэдний гэдгийн эсрэг утга; бидний, өөрийн; *манай гэр; манай улс.* ᠮᠠᠨᠠᠢ

МАНАЙХ тэднийх гэдгийн эсрэг утга; 1. манай гэр орон; *манайх нүүгээд ирсэн; манайх энэ жил малаа өсгөв; малгай тавивал манайх, маргааш бол хүнийх* з ү й р; 2. манай юм; *энэ түрүүлж ирсэн хүр дэлтэй бор азрага манайх.* ᠮᠠᠨᠠᠢᠬᠠᠨ

МАНАЙХАН тэднийхэн гэдгийн эсрэг утга; өөрийнхөн; *манайхан төлөвлөгөөгөө биелүүлэв.* ᠮᠠᠨᠠᠢᠬᠠᠨ

МАНАН 1. усны уур дүүрсэн тунгалаг бус агаар; *манантай өдөр;* **манан будан** х о р ш.; *манантай өдөр байна, харанхуй болноо хөө хөө, мандах наран гараад ирвэл тунгалаг болно хөө хөө* (ардын дуу) 2. тоос, утаа; **тоос манан, утаа манан** х о р ш.; **улаан манан татуулах** (тоос ихэд бужигнах); 3. ш и л ж с э н үймээн, бужигнаан; **сүйдийн манан болох** (ихэд сандрах, бужигнах); **манан хадаах** (үймүүлэн сандраах). ᠮᠠᠨᠠᠨ

МАНАНТАХ манан татаж түгээмэл болох. ᠮᠠᠨᠠᠨᠲᠠᠬᠤ

МАНАНТУУЛАХ манантахын үйлдүүлэх хэв. ᠮᠠᠨᠠᠨᠲᠤᠤᠯᠠᠬᠤ

МАНАРАХ 1. бүдэнгэрэх, будангуйрах; *утаа манарах; тоос манарах;* 2. ш и л ж с э н балардах, харанхуйлах; *ухаан манарах; толгой манарах.* ᠮᠠᠨᠠᠷᠠᠬᠤ

МАНАРГАХ манарахын үйлдүүлэх хэв, манарахад хүргүүлэх; *төос манаргах.* ᠮᠠᠨᠠᠷᠭᠠᠬᠤ

МАНАРУУЛАХ манарахын үйлдүүлэх хэв. ᠮᠠᠨᠠᠷᠤᠤᠯᠠᠬᠤ

МАНАХ I дарж хучих, битүүлэх; *гэрийн хаяа манах шороо;* **хаяагаа манах** (бусдаас болгоомжилж, хянамжлах, урьдаас цагаатган мэдэгдэх); **гал манах** (цогийг унтраахгүйн тул үнсээр хучих).

МАНАХ II 1. манаанд гарах; *манаа манах; адуу манах; хот манах;* 2. цагдах, хянаж сэргийлэх; **манах цагдах** х о р ш..

МАНГАД мангас.

МАНГАН химийн нэг зүйл язгуур махбод, улаан хүрэн өнгийн төмөрлөг; *мангааны хүдэр.*

МАНГАР эргүү балай, моншин дүйнгэ; *мангар амьтан; мангар хүн;* **мангар тайлах** (согтуурах унд уусны дараа өдөр шар тайлж мөн унд уух).

МАНГАРЛАХ мангар болох, дүйнгэрэх, мангуурах.

МАНГАРТАХ мангар байдал гаргах.

МАНГАС үлгэрт гардаг хүн дүрстэй муухай амьтан; *арван таван толгойт атгаалжин хар мангас.*

МАНГИНА у р г а м а л **мангирын** нэг зүйл.

МАНГИР у р г а м а л хээр ургадаг, сонгиной төрлийн нэг зүйл ургамал, амт ааг сармистай төстэй, иш нь анх ургахдаа хавтгайлаг байгаад хожим цоорлоно.

МАНГИС I дорго.

МАНГИС II у р г а м а л мангирын нэг зүйл; **мангисан сүүл** у р г а м а л (хээр ургадаг, иш нэг, навч нь сарнаг цэцгийн навчтай адил болоод төрүүтнэ, амт хүчтэй, түүхийгээр нь идэг нэгэн зүйл ногоо).

МАНГУУ тэнэг, мунхаг, дүйнгэ, маанаг; *мангуу хүн.*

МАНГУУДАХ хэтэрхий мангуу болох.

МАНГУУРАХ мангуу болох; *чи битгий мангуураад байгаарай!*

МАНГУУРУУЛАХ 1. мангуурахын үйлдүүлэх хэв, мангуу болгох; 2. санаа сэтгэлий нь эргүүтүүлэн төөрүүлэх, самууруулах.

МАНГУУТАХ мангуу байдал гаргах.

МАНГУУХАН баахан мангуу.

МАНГУУШИХ мангуу шинжтэй болох.

МАНДАА шашны ёсны тахил тавиглалын суурь дугуй хэрэгсэл; *мөнгөн мандаа; гуулин мандаа.*

МАНДАЛ I мандах үйлийн нэр, бадрал, дэлгэрэл: **мандал бадрал** х о р ш..

МАНДАЛ II шашны ёсны нэгэн зүйл тахил тавиглал; *бурханд мандал өргөх; ламд мандал өргөх.*

МАНДАЛ III юмны өнгөн талын ерөнхий түвшин; *далайн мандал; сарны мандал; газрын мандал;* **усан мандал** (манай дэлхийг бүрхсэн усан бүрхэвч); **агаар мандал** (манай дэлхийг бүрхсэн хийн бүрхэвч).

МАНДАЛТ: **мандалт цэцэг** у р г а м а л иш нь ногоон, навч нь илжгэн чихний навчтай адил болоод ногоовор, цэцгийн өнгө цагаан, зургаан хэлтэстэй, эрт цэцэглэж үдэш хамхина.

МАНДАРИВАА у р г а м а л салаатай уртхан навчтай, цэцгийн цоморлиг нь том, сайхан үнэртэй, гоёлын ургамал, өнгө зүйл бүр бий.

МАНДАРИН бэрсүүт жүрж.

МАНДАТ бүрэн эрхтэй болохыг гэрчилсэн үнэмлэх баримт; **мандатын комисс** (мандат шалгах комисс).

МАНДАХ 1. гарах, асах; *нар мандах; зул мандах;* 2. бадрах, хөгжих, дэгжих, дэлгэрэх; *мандан хөгжиж яваа манай хувьсгалт орон; дэлхий дахинаа энх тайван, эв найрамдал мандах болтугай!* 3. нэрд гарах, алдарших; *нөгөө чиний хэлж байсан залуу чинь сайн мальчин болоод мандаж явна гэнэ.*

МАНДГАР бандгар тарган, бүдүүн том.

МАНДЛАХ үүсэх өрнөх, дээшлэх өөдлөх.

МАНДОЛИН чавхдаст хөгжмийн зэвсэг; *мандолин цохих.*

МАНДТУГАЙ мандахын ерөөх төлөв; *манай хайрт Эх орон-Бүгд Найрамдах Монгол Ард Улс мандтугай!*

МАНДУУЛАХ мандахын үйлдүүлэх хэв; *улаан туяа мандуулах; улс орноо мандуулах; өчигдрийн хурал дээр чамайг ч харин нэг мандуулж байна билээ дээ.*

МАНЁВР 1. дайны үед дайсныг цохихын тулд хуурай болон усан замын цэргүүд байраа сэлгэх ажиллагаа; *бүслэх манёвр;* 2. цэргийн хээрийн сургууль; *манёврт явах.*

МАНЕВРЛАХ маневр хийх.

МАНЖ I 1. зөрчид ястан; 2. зөрчид аймгийн хүн; *манж үсэг* (манж ястны хэрэглэж байсан үсэг).

МАНЖ II бие ба өвэр маш том хандгай.

МАНЖ III хурал ном хурж байгаа лам нарын уух цай.

МАНЖИН у р г а м а л том бөөрөнхий, амтлаг үндэстэй идэшний ногоо; *улаан манжин; шар манжин;* **чихрийн манжин** (чихэрлэг ихтэй, цагаан үндэстэй.

МАНЖЛАГА 1. биедээ унжуулж зүүх чимэг, эрдэнийн зүйлээр ч хийнэ, эд бөсөөр ч хийнэ; *ташаадаа манжлага зүүжээ;* 2. жанч нөмрөгийн захны залгаасанд унжуулах салбан; *нөмрөгийн манжлага.*

МАНЖЛАХ хурлын лам нарын манж уух.

МАНЖУУХАЙ I у р г а м а л хээр ургадаг, идэр ногооны язгууртай адил болоод амтайхан нэгэн зүйлийн идэшний ногоо.

МАНЖУУХАЙ II: **манжуухай цэцэг** у р г а м а л хээр ургадаг, цагаавтархан өнгөтэй нэгэн зүйл цэцэг.

МАНЖУУХАЙ III муухай.

МАНЗ манж III.

МАНЗШИГА у р г а м а л мөнгөн цацагт цэцгийн адил болоод цав цагаан өнгөтэй, няг хүйстэй нэгэн зүйл цэцэг.

МАНИГАР нүүр махлаг, нүд анигар, үзэмж сайн биш; *манигар царайтай; болхи манигар амьтан.*

МАНИЙ бидний, манай олны.

МАНИЙХ манигар болох.

МАНИН бэлгийн эрхтэн саармаг, эр эм бэлэг хосолсон буюу эсхүл ээлжилж эр эм бэлэгтэй болох хоёр зүйл байдаг; **манин саармаг** х о р ш..

МАНЛАЙ 1. тэргүүн юм; **манлайд явах** (тэргүүнд явах); **манлай морь** (тэргүүлсэн морь); 2. ш и л ж с э н дээд зэргийн; *адуун сургийн манлай, агт морьдын тэргүүн; манлай сайн;* 3. магнай.

МАНЛАЙЛАЛ манлайлах үйлийн нэр; *намын гишүүдийн манлайлал.*

МАНЛАЙЛАХ 1. манлай болох, тэргүүлэх; *пролетарийн манлайлах удирдлага;* 2. дээд сайн, тэргүүн зэрэгт тооцогдох; *манлайлж гарах.*

МАНЛАЙЛУУЛАХ манлайлахын үйлдүүлэх хэв, манлай болгох.

МАНЛАЙЧЛАХ удирдан хушуучлах; *манлайчлах хэсэг.*

МАНТАЙХ мантгар болох.

МАНТГАР 1. толгой том, нүүр махлаг; 2. үзүүр этгээд бүдүүн монцгор.

МАНТУУ гурилыг исгэж, жигнэн хийсэн нэг зүйл идээ; *чихэртэй мантуу; шанзтай мантуу; мантуу жигнэх.*

МАНТУУЛИГ: мантуулиг төмс у р г а м а л улаан чавга мэт том нэгэн зүйл жимс.

МАНУУЛ I а м ь т а н хээрийн муур, бие тэжээвэр мууraас том, өнгө шаравтархан, бидэртэй.

МАНУУЛ II мануухай.

МАНУУЛАХ 1. манахын үйлдүүлэх хэв; 2. манагдах.

МАНУУЛЧ харуул манааг эргэж цагдан явах хүн.

МАНУУХАЙ 1. чононоос сэргийлэн малын хотны захад босгосон хүний дүрс, дээл, хүрэм мэт зүйл; *мануухай босгох;* 2. ш и л ж с э н өөдгүй, чадал муутай, толгой мэдэлгүй хүн; *хүн биш мануухай.*

МАНУХ нэг зүйл үнэт чулуу, өнгө зүйл бүр, хөөрөг зэрэг зүйл хийнэ.

МАНХ (АН) бөөн их элс, элсэн гүвээ, элс ихтэй гүдгэр; элс манх х о р ш.; *манхны маань дээгүүр, манан хүдэн татна* (ардын дуу).

МАНХАГ эм агуулах хуннастай таарцаг сав.

МАНХАГЛАХ манхагт агуулах, хийх.

МАНХАЙХ 1. гэгээ орж, саруул тэнүүн болох; *үүр манхайтал цайв; сар манхайтал мандав;* 2. манхгар болох.

МАНХАН морины чилбэн цагаан зүстэй; *манхан цагаан морь;* манхан үхэр (бие хар, толгой цагаан эсхүл бие цагаан толгой хар зүстэй үхэр).

МАНХАР халзнаас өргөн, толгой нүд ам орчин бүрэн цагаан үс ургасан нь; *манхар үхэр; манхар халзан.*

МАНЦАР чулуулгийн нунтаг, талх.

МАНЦУЙ нялх хүүхдийг өлгийдөх, боох нэхий бөс мэтээр хийсэн өлгий; *манцуйтай хүүхэд.*

МАНЦУЙЛАХ өлгийдөх.

МАНЦУЙЛУУЛАХ манцуйлахын үйлдүүлэх хэв.

МАНЦУУ нүдүүр, манцуурга.

МАНЦУУДАХ манцуугаар нүдэх.

МАНЦУУЛАХ манцуугаар дэлдэх.

МАНЦУУРГА шийдэм, нүдүүр, манцуу; *төмөр манцуурга.*

МАНЦУУРГАДАХ манцуургаар цохих.

МАНЦУУРГАЛАХ манцуургадах.

МАНШУУН дүйрэнгэ, мунганууи, мангуу.

МАНЬ ш о о д с о н, үл тоомсорлосон байдлыг илэрхийлэх зүйлд хэрэглэнэ; *мань эр юу гэж яваа вээ? мань тэр ирсэн гэдэг; мань өвгөн сайн уу?.*

МАР: **мар мар хийх** хүний үргэлж ярвиглан хэлэлцэх; **мар мур хийх** (ялимгүй хэрүүл болох, тар түр хийх).

МАРАА марз; **марз мараа, хужир мараа** х о р ш.; *мал мараа долоож байна.*

МАРАЛ I эм буга, согоо ч гэнэ; **марал цэцэг** у р г а м а л нийлмэл цэцгийн язгуурын өвсөрхөг ургамал, шар өнгийн саг маягийн цэцэгтэй, навчны доод тал цайвар ногоон, эмнэлэгт хэрэглэнэ).

МАРАЛ II з у р х а й одны нэр; *гурван марал.*

МАРАМГАР хамар ам нүүр нь барчгар хүн.

МАРГАА маргах хэцүү, маргадаг, маргалдаан; *маргаа хүн.*

МАРГААД маргааш.

МАРГААДАР маргааш, маргаашийн өдөр.

МАРГААН үгийн булаалдаан, маргалдаан, тэмцэл, татгалзал; *дэмий маргаан болох хэрэг алга;* **маргаан тэмцээн, хэрүүл маргаан, маргаан будлиан** х о р ш..

МАРГААНГҮЙ зөрөх маргах зүйлгүй; *маргаангүй үнэн хэрэг; ямар ч маргаангүй; маргаангүй сайн.*

МАРГААЧ дандаа маргадаг зантай.

МАРГААШ ирэх өдөр, эсрэгэн өдөр, дараа өдөр, маргаадар; *та маргааш ир!* **маргаашийн маргааш** (нөгөөдөр); *маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушиг дээр* (хожмын сайнаас бэлэн муу дээр).

МАРГАД хурц ногоон өнгөтэй эрдэнийн чулуу; *маргад эрдэнэ; маргад шигтгэсэн бөяжиг.*

МАРГАЛДААН маргаан, тэмцээн; *маргалдаантай асуудлыг шийдвэрлэх.*

МАРГАЛДАХ харилцан маргах, тэмцэх; *та нар битгий маргалд, би маргааш хариугий нь хэлж өгье.*

МАРГАЛДУУЛАХ маргалдахын үйлдүүлэх хэв.

МАРГАМТГАЙ маргах зантай, ихэд маргадаг.

МАРГАМХАЙ маргамтгай.

МАРГАСАР з у р х а й сарны зурхайн ёсны хорин найман одны нэг.

МАРГАСХИЙХ баахан маргах; *нилээд маргасхийсэн болович зөвшөөрөв.*

МАРГАХ үг булаалдаж тэмцэх, цааргалах, татгалзах; *маргах хэрэг алга; зөв бурууг маргах;* **маргах эсэргүүцэх** х о р ш..

МАРГУУЛАХ маргахын үйлдүүлэх хэв.

МАРЗ (АН) мал гөрөөсний идэх шор мараа, хужиртай газар; **марзад суух** (буга гөрөөс марзад ирэхийг отож суух).

МАРЗАГНАХ марзан зан ааль гаргах; *чи битгий марзагнаад байгаарай!*

МАРЗАГНУУЛАХ марзагнахын үйлдүүлэх хэв.

МАРЗАЙЛГАХ марзайхын үйлдүүлэх хэв.

МАРЗАЙХ марзгар болох.

МАРЗАЛЗАХ марзгар юмны марзас марзас хөдлөх.

МАРЗАН саваагүй, юм юманд хурч оролцож явдаг, гажуу зантай; *марзан хүн.*

МАРЗГАНАХ марзгар юмны марзга марзга хөдлөх, аашлах.

МАРЗГАР шүд арзгар, зан байдал марзан.

МАРЗЛАХ мал гөрөөсний марзад орох.

МАРИА мах; **мах мариа** х о р ш.; *мариатай хүүхэд; мариа суух;* **мариатай** (махлаг гарган); **мариа муутай** (туранхай, эцэнхий).

МАРИАЖИХ мариалах, мариа суух.

МАРИАЛАХ махлах, таргалах; *миний хүү мариалж байна.*

МАРИАЛУУЛАХ мариалахын үйлдүүлэх хэв, мариа суулгах.

МАРИЛ у р г а м а л өнгө улаан, хэлбэр бөв бөөрөнхий нэг зүйл жимс.

МАРК шуудан зэрэгт төлбөр хураалгасны тэмдэг болох зураг мөнгөний тоо бүхий бяцхан цаас, захидал, бичиг зэрэг юманд наана; *арван таван мөнгөний марк; маркийн цуглуулга;* 2. худалдааны тэмдэг, бараан дээрх тамга; *фабрикийн марк; ямар маркийн дугуй вэ?*

МАРКСИЗМ байгаль нийгмийн хөгжлийн тухай, дарлагдан мөлжигдөгч хөдөлмөрчин олны хувьсгалын тухай, бүх улс оронд нийгэм журамт ёс ялах тухай, эвхамт ёсыг бүтээн байгуулах тухай шинжлэх ухаан; **марксизм-ленинизм** (Маркс, Энгельс, Лениний сургаал).

МАРКСИСТ марксизмыг баримтлагч; *марксист онол; марксист сургаал; марксист нам.*

МАРЛИГАНАХ марлигар юмны марлига марлига хөдлөх.

МАРЛИГАР эв хав муутай том нүүртэй; *марлигар хар хүн.*

МАРЛИЙХ марлигар болох.

МАРЛИЛЗАХ марлигар юмны марлис марлис хөдлөх.

МАРМАА: мармаа сугас а м ь т а н зарам загасны төрлийн хэндэл загасанд адил бөгөөд өнгө улбар нэгэн зүйл загас.

МАРМАГАНАХ мармагар юмны мармага мармага хөдлөх.

МАРМАГАР эв хавгүй хавтгай нүүртэй.

МАРМАЙЛГАХ мармагар болгох.

МАРМАЙХ мармагар болох.

МАРМАЛЗАХ мармагар юмны байн **байн** хөдлөх.

МАРТАГДАХ мартахын үйлдэгдэх хэв,

МАРТАГДАШГҮЙ мартагдах аргагүй мартмаагүй; *хүнд мартагдашгүй үе бол залуу нас байдаг.*

МАРТАГДУУЛАХ мартагдахын үйлдүүлэх хэв.

МАРТАГНАХ юмыг түр зуур мартах.

МАРТАГНУУЛАХ мартагнахын үйлдүүлэх хэв.

МАРТАМТГАЙ их мартдаг.

МАРТАМХАЙ мартамтгай; *ямар мартамхай хүн бэ?*

МАРТАХ мэдсэнээ мэдэхгүй болох, юм сэтгэлд орж санагдахгүй болох, дурсан санахгүй болох; *мартана гэдэг маниас урьдын юм х у у ч; чамд хэлэх гээд мартаж орхижээ; чи битгий мартаарай; би чамайг хэзээд мартахгүй; өнөөхий чинь таг мартаж орхижээ.*

МАРТАШГҮЙ мартах аргагүй, мартмаагүй.

МАРТЕН: мартен зуух болд хайлуулах зуух.

МАРТНИХ мартагнах.

МАРТНИУЛАХ мартнихын үйлдүүлэх хэв.

МАРТУУЛАХ мартахын үйлдүүлэх хэв.

МАРТУУШТАЙ мартвал зохих юм; *тэр чинь ёстой л мартууштай зүйлийн нэг мөн.*

МАРЧГАНАХ марчгар юмны хөдлөх.

МАРЧГАР нүүр царай нь **нөрөө** ихтэй барчгар.

МАРЧИЙЛГАХ марчийхын үйлдүүлэх хэв, марчгар болгох.

МАРЧИЙХ марчгар болох.

МАРЧИЛЗАХ марчгар юмны марчис марчис хөдлөх.

МАРШ I 1. цэргийн аялал; *хоёр хоногийн марш;* 2. алхах айзамд тохируулан зохиосон хөгжмийн зохиол; *хувьсгалт цэргийн баатарлаг марш үлээвэр хөгжимд тоглов.*

МАРШ II яв! алх! гэсэн тушаал команд; *алхаад марш!*

МАРШАЛ өрлөг.

МАРШЛАХ алхлах, аялах, аяллаар явах.

МАРШРУТ зам, явах зорчих зам; *онгоцны маршрут; хөдөө явах маршрут.*

МАССАЖ барьж илбэж засах арга; *массаж хийлгэх; массаж хийх.*

МАСТЕР 1. үйлдвэрийн аль нэгэн тухайлсан юм хийж үйлдвэрлэх газрын удирдагч, мэрэгжилтэн; *ээлжийн мастер;* 2. аль нэг зүйлд мэрэгжсэн ажилтан; *хувцасны мастер; гутлын мастер; мод харуулдахдаа ч мөн мастер байна шүү;* 3. тэргүүний тамирчдад олгох цол; *шатрын мастер.*

МАСШТАБ зураг дээрх уртын хэмжээ жинхэнэ газар дээрх хэмжээ хоёрын харьцаа; *таван километрийг нэг сантиметрт багтаасан масштаб.*

МАТАА жижигхэн махир хутга сэлэм.

МАТААС юмыг матигар болгож матсан нь; *матаас нь ихдэх.*

МАТАГДАХ матахын үйлдүүлэх хэв.

МАТАЛЗАХ матас матас хийх.

МАТАЛЗУУЛАХ маталзахын үйлдэгдэх хэв.

МАТАР амьтан дулаан оронд оршдог хэвлээр явагч том амьтан, усны мангас ч гэдэг; *далайн матар; матрын цус;* **матарны толгой;** **матрын зам** (дэлхийн халуун **бүсийн өмнөд** хэсгийн зааг уртраг шугам).

МАТАХ 1. юмыг залж засч муруй, махир, дугуй, матигар болгох; *тоонын хүрээ матах; ханын мод матах;* 2. махир юмаар нааш нь татах.

МАТГА матаа.

МАТГАНАХ матгар юмны матга матга хийх.

МАТГАР матсан мэт эртгэр, махир; *матгар сэлэм.*

МАТЕМАТИК тооны ухаан.

МАТЕМАТИКЧ математикт мэрэгжсэн хүн.

МАТЕРИАЛ хэрэглэгдэхүүн юм; 1. түүхий эд; **эд материал** хорш.; *барилгын материал;* 2. мэдээ сэлт; *Үнэн сонины материал; материал цуглуулах; материал бүрдүүлэх;* 3. бөс даавуу; *костюмын материал авах санаатай явж байна.*

МАТЕРИАЛИЗМ ухамсар анхдагч гэдэг идеализмын эсрэг гүн ухааны үндсэн чиглэл бөгөөд матери анхдагч, бодит ертөнц бол ухамсраас хараат биш гэж үзнэ; **диалектик материализм** (байгалийн үзэгдлийг диалектик аргаар материалист ёсоор танин мэдэхэд үндэслэсэн марксист ленинист гүн ухаан); **түүхийн материализм** (нийгэмлэгийн хөгжлийн ерөнхий хуулиудын тухай шинжлэх ухаан).

МАТЕРИАЛИСТ материализмыг баримтлагч; *материалист гүн ухааны мөн чанар.*

МАТИГАР матгар, матайсан нь.

МАТИЙЛГАХ матигар болгох.

МАТИЙХ матигар болох.

МАТЛАГА матаж матгар болгох нь, матаас.

МАТМАЛ матаж хийсэн юм; *матмал тооно; матмал сандал.*

МАТРАХ юмны матсан мэт болох, махир болох.

МАТУУЛАХ матахын үйлдүүлэх хэв.

МАУЗЕР нэг зүйл автомат буу.

МАХ (АН) амьтан, ургамлын яс арьс хоёрын завсар дахь нэхдэс; *хонины мах; гахайн мах; ангийн мах; шувууны мах; чавганы мах; чангаанзны мах;* **тарган мах** (өөх ихтэй мах); **шинэ мах** (сая нядалсан малын мах): **хуучин мах** (нядлаад удсан мах); бүхэл мах (хөшиглөөгүй мах; *бүхэл мах идэх);* **тураг мах** (толгой шийр, гэдэс дотроос бусад мах); **мах болгох** (а. мал нядалж бэлтгэх; б. маш ядрааж хөдөлгөөнгүй болоход хүргүүлэх); **хар мах** (өөхгүй мах); **өрөөл мах** (тал мах); **шар мах** (арьс ширний дотор талд наалдаж байх нимгэн хальс); **цагаан мах** (хошгиногийн бүдүүн үзүүр); **улаан мах** (түүхий мах); **махан баримт** (бие баримт); **махан хоол** (дан мах буюу махтай хоол); **махан хуурга** (хуурсан мах): **мах бэлтгэл** (улсын төлөвлөгөөт мал бэлтгэл); **махны дэлгүүр** (мах худалдах дэлгүүр); **махны мухлаг** (мах худалдах мухлаг); **махны тэрэг** (мах зөөх тэрэг); **мах комбинат** (мал нядлах, махны үйлдэхүүн хийх үйлдвэр); **мах болох** (маш ядарч хөдөлгөөнгүй болох); **махаа идэх** (зовлонгоо эдлэх); **мах идэх** (а. махан хоол идэх; б. зовох зүдэх): **махан овоо хийх** (дээр дээрээсээ овооролдох); **мах мариа** (тарга тэвээрэг); **мах татах** (а. махыг маш жижигхэн хэгж хөшиглөх; б. мах суух); **мах нь суух** (мах шуурах); **мах шуурах** (эцэж туранхилах); **мах суух** (таргалж мах нэмэгдэх); **мах цусны, мах ясны** (ураг төрлийн; *мах цусны барилдлага);* **махан бие** (зэр зэвсэгүй дан бие; *аав ээжийн заясан махан биеэрээ үзэлцэх үү?* (үлгэр); **ямааны мах халуун дээрээ** (юм шинэ сэрэг дээрээ дээр); *малын түрүүнд бух, махны түрүүнд үүц* зүйр.

МАХАЙЦАХ маахайцах.

МАХАРХАГ мах ихтэй, махархуу.

МАХАРХУУ мах ихтэй, махархаг.

МАХВОД түмэн бодисын бүтсэн эд; **язгуур махвод** (уул бүрэлдэн тогтсон анги хэсэгтээ ердийн химийн аргаар үл задрах энгийн бодис); **бие махвод** (харилцан зохицон хөдөлж ажиллах эрхтэн бүхий амьтан буюу ургамал).

МАХИГАР махир, тахигар; *махигар үүрга.*

МАХИЙЛГАХ махигар болгох, тахийлгах.

МАХИЙХ махигар болох, тахийх.

МАХИР махигар, муруй, тахир; *махир савваа; махир гудамж.*

МАХЛАГ тарган, мах ихтэй; *махлаг царайтай.*

МАХЛАХ I таргалах, мах ихтэй болох.

МАХЛАХ II эцээх, зовоох, зүдрээх.

МАХЛУУЛАХ 1. махлахын үйлдүүлэх хэв; 2. махлагдах.

МАХРАНЗ шашны ёсны үйл сахигч их хаан.

МАХРАХ мэрийх, чармайх, үнэхээр хичээх; *үнэхээр махран ажиллаж билээ.*

МАХРУУ мэриймтгий, шамдамхай, хичээлтэй; махруу оролдох; *ажилдаа махруу хүн.*

МАХСААХ махсахын үйлдүүлэх хэв.

МАХСАХ I мах идэхийг хүсч мөрөөдөх; *зун цагт их махсадаг байв.*

МАХСАХ II махрах ,мэрийх, улайх.

МАХСАХГҮЙ I мах идэхийг хүсэхгүй.

МАХСАХГҮЙ II мэрийж хүчлэхгүй, махрахгүй.

МАХСУУ I мах идэхийг мөрөөдөн хүсэмтгий.

МАХСУУ II махруу, шамдамгай.

МАХТАЙ I 1. тарган, махлаг, мах ихтэй; 2. мах бүхий; *махтай шөл.*

МАХТАЙ II зориг тэсвэр сайтай, махандаа сайн.

МАХЧИН 1. бусад амьтныг барьж идэгч; *махчин шувуу; чоно-махчин амьтан;* 2. хүний мах иддэг зэрлэг хүн; *махчны тухай үлгэр домог;* 3. ш и л ж с э н хүнийг тарчлаан тамлагч; *махчин фашистууд.*

МАХЧЛАХ I бусдыг тарчилган зовоох.

МАХЧЛАХ II ном бичгийг яг үгчлэн хөрвүүлэх; *махчилж орчуулснаас утгачилж орчуулбал дээр.*

МАХЧЛУУЛАХ 1. махчлахын үйлдүүлэх хэв; 2. махчлагдах.

МАХЬ усны үхрийн өөр нэр.

МАЦААХ мацахын үйлдүүлэх хэв.

МАЦАГ буддын шашны ёсонд мах идэхгүй, үдээс хойш идээ идэхийг цээрлэх санваар; **мацаг барих** (мах идэхгүй өнжих санваарыг сахих).

МАЦАГЛАХ мацаг барих.

МАЦАГТАЙ мах иддэггүй хүн.

МАЦАЛХИЙЛАХ 1. шамдан шаардан явах; 2. бай булаалдах, байн төлөө тэмцэх.

МАЦАХ 1. өндөр өөд арайхан чарман явах; *өөдөө үлэмж мацна;* 2. ш и л ж с э н хөдөлмөрт мэрийн зүтгэх.

МАЦАХААР алдавч оновч дүүрсэн хэрэг гэж нэгэнт шийдвэрлэсэн санаа; *мацахаар зүтгээд биеэ гээсэн ч гомдолгүй.*

МАЦУУЛАХ мацахын үйлдүүлэх хэв, мацаах.

МАШ I нэн, онц гэсэн утгатай хүч нэмэгдүүлэх үг; *маш сайн; маш хурдан явав; маш хүчтэй; маш цөөн;* **маш эрхэн** (охь манлай); **маш ихэд** (тэсгэлгүй); **маш дэлгэмэл** (арван дөрвөн оронтой тоо).

МАШ II цахиур буугийн гал бялтыг хавчуулж буудахад гал үүсгэх хавчуур төмөр.

МАШИД үүрд, нэгмөсөн, бүрмөсөн; **машид цээрлэх** (үүрд цээрлэх).

МАШИН (А) 1. нэг янзын хүчийг нөгөөд хувилган ямар нэгэн хэрэгтэй ажлыг бүтээх механизм (оньсон хүрд); *үүрэн машин; нэхэх машин; оёдлын машин; машинын тос; бичгийн машин; сүүний машин; махны машин; тооны машин; сахлын машин; үсний машин; өвсний машин;* **суурь машин** (ямар нэгэн юм боловсруулан хийж үйлдэх машин; *хэвлэлийн суурь машин);* **машинын бичээч** (машинаар бичиг бичих хүн); 2. я р и а автомобиль; *ачааны машин; суудлын машин; машинын дугуй.*

МАШИНДАХ машинаар юм хум хийх, үйлдвэрлэх; *мах машиндах; бичиг машиндах;*

МАШИНДУУЛАХ машиндахын үйлдүүлэх хэв.

МАШИНЖИХ машинтай болох, олон машинтай болох.

МАШИНЖУУЛАХ машинжихын үйлдүүлэх хэв.

МАШИНИСТ машинч; *галт тэрэгний машинист.*

МАШИНЧ машинаар ажилладаг хүн.

МАШИНЧЛАХ юмыг машинаар үйлддэг болгох.

МАШЛАХ 1. юмыг нэгмөсөн болгох; 2. хамтатгах, умшлах; 3. юмыг үүрд өгөх авах.

МАШУУ хоол хэтэрснээс болж гэдэс дотор өвдөх өвчин.

МАШУУДАХ хоол хэтэрснээс болж дотор аягүйцэх.

МАШУУТАХ машуу өвчин тохиох.

МАЯА I далны ясны нарийн үзүүр; *далны маяа*

МАЯА II гоожиж байгаа шингэн зүйлийг тосч авах ховилтой тосуур цорго.

МАЯАРАА тогос шувуу.

МАЯГ I юмны эх, үлгэр, загвар, хэлбэр, дүрс; **үлгэр маяг, загвар маяг, хэлбэр маяг, дүрс маяг** хорш.; *дугуй маягийн ширээ; шинэ маягийн хувцас; маягий нь таарууллах;* **маяг татах** (маяг хийх); **арга маяг** (арга хэлбэр, арга барил, ажлын арга барилыг өөрчлөх).

МАЯГ II гажуу зан авир; *маяг гаргах; хоосон маяг хэнд ч хэрэггүй.*

МАЯГГҮЙ I жигтэйхэн их; *маяггүй их ус; маяггүй хүйтэн өдөр;.*

МАЯГГҮЙ II ааш авир нь олдохгүй; *маяггүй хүний цадиггүй зан.*

МАЯГЛАХ I 1. маяг загвары нь буулган авах; 2. юманд маяг оруулан янзлах.

МАЯГЛАХ II гажуу зан авир гаргах; *чи битгий маяглаад бай!*

МАЯГЛУУЛАХ маяглахын үйлдүүлэх хэв, маяглахад хүргүүлэх.

МАЯГСАХ маяг хэрэглэх гэх; *маягсаад байх юу байх вэ, болохоор нь хийчихгүй юу.*

МАЯГТ маяг бүхий; *нэгдүгээр маягт; тавдугаар маягт.*

МАЯГТАЙ I маяг загвар бүхий юм.

МАЯГТАЙ II зан ааш муутай, ихээр байдалтай, олон ааштай; *яасан маягтай юм бэ!*

МЕДАЛЬ гавъяа байгуулагсдад олгох тусгай тогтоосон хэлбэр бүхий тэмдэг; *хөдөлмөрийн хүндэт медаль; Дөчин жилийн ойн медаль; алтан медаль; хүрэл медаль.*

МЕНЬШЕВИК марксизмын өсрэг оппортунист намын гишүүн; меньшевик нь социалист хувьсгал ялсны дараа Орос орон дахь буржуйлэгүүдийн түшиг тулгуур, гагнуул, хорлон сүйтгэгч дайсан болж хувирсан юм.

МЕРИНОС 1. нарийн ноост хонины нэг үүлдэр; *меринос хонь;* 2. мөн хонины ноос, арьс; *мериносон дотортой дээл.*

МЕРС: мерс яр арьс өнгөний нэг зүйл халдварт өвчин.

МЕТАЛЛ төмөрлөг; **хар металл** (төмөр, ширэм, болд); **өнгөт металл** (зэс, тугалга, никель зэрэг); **ховор металл** (алт зэрэг).

МЕТАЛЛУРГИ металл боловсруулан гаргах тухай шинжлэх ухаан; **металлургийн комбинат** (металл боловсруулан гаргадаг үйлдвэр).

МЕТАФИЗИК дэлхий ертөнцийг бурхнаас заяасан бөгөөд үзэгдэл юмсыг харилцан холбоогүй, хөдөлгөөнгүй, хувьсал хөгжилгүй гэж номлодог идеалист үзэл ухааны харгис номлол.

МЕТАФИЗИКЧ метафизикийн талыг баримтлагч идеалист.

МЕТР 1. уртын хэмжүүрийн аравтын системийн үндсэн хэмжих нэгж, болох уртын нэгж меридианыг 40000000 хуваасны нэгтэй тэнцэнэ; *дөрвөлжин метр; босоо дөрвөлжин метр;* 2. мөнхүү хэмжээний урт нарийн мод; **метрийн даалимба** (метрлэж худалддаг даалимба.

МЕТРО том хотуудад газар доогуур тавьсан цахилгаан тэрэгний төмөр зам; *метрогоор явах.*

МЕХАНИЗМ машин, багаж хэрэгсэл, аппарат зэрэг юмсыг хөдөлгөж чадах оньс; *цагийн механизм; өргөх механизм.*

МЕХАНИК машины ажиллагааг хариуцагч, механик.

МЕХАНИКА юмны хөдөлгөөн, хүчний тухай сургаал, механика бол физикийн нэг салбар ухаан болно.

МЕХАНИКЖИХ гараар хийдэг ажлыг механик оньсон хүчээр, машинаар хийдэг болох.

МЕХАНИКЖУУЛАХ механикжихын үйлдүүлэх хэв; *гар ажиллагааг механикжуулах.*

МЕХАНИКЧ машины ажиллагааг хариуцагч; *баазын механикч; кино механикч; засварын механикч.*

МИГУЙ эм мий; *муу хүн биеэ магтана, мигуй хэржингээ магтана* зүйр; **мигуйн нүд** (болрын төрөл, шар буюу ногоон өнгөтэй чулуу, бөөрөнхийлөн зассан нь муурын нүдтэй төсөөтэй, чимгийн зүйлд хэрэглэнэ).

МИГУЙС амьтан малууртай адил бөгөөд хөхөлтэй нэг зүйл гөрөөс.

МИЙ муурын ерөнхий нэр.

МИКРОБ бичил.

МИКРОБИОЛОГИ бичил амин судлал.

МИКРОН метрийг нэг сая хуваасны нэг буюу миллиметрийг нэг мянга хуваасны нэг.

МИКРОСКОП бичил дуран, энгийн нүднээ үл үзэгдэх бичил биеийг харах дуран.

МИКРОФОН дууг алсад дамжуулахын тулд авианы хэлбэлзлийг цахилгаан хэлбэлзэл болгож хувиргах хэрэгсэл; *микрофоны өмнө үг хэлэв.*

МИЛ мий.

МИЛИТАРИЗМ цэрэг дайны түрэмгий бодлого.

МИЛИТАРИСТ цэрэг дайны үзэлтэн.

МИЛЛИГРАММ хүндийн хэмжүүр, граммыг мянга хуваасны нэг хувь.

МИЛЛИМЕТР метрийг мянга хуваасны нэг хувь.

МИЛЛИМИКРОН микроны мянган хувийн нэг.

МИЛЬ уртын хэмжээ; **газрын миль** (7420 метртэй тэнцүү хэмжээ): **далайн миль** (1852 метртэй тэнцүү хэмжээ).

МИЛЭЭД нилээд.

МИН: **мин царцаахай** амьтан хөдөө аж ахуйн хорлогчин шавьж, тарианы голыг иддэг.

МИНА 1. газар, усан дор гавих тэсрэх тусгай сум; *танк эсэргүүцэх мина; усан дорхи мина;* 2. мина харвуулын сум; *миныг харвуул; минаар буудах буу.*

МИНЕРАЛ эрдэс; *минералын бордоо; минералын будаг; минералын давс.*

МИНЖ (ИН) амьтан мэрэгчний багийн үнэтэй үст амьтан; *минжин малгай; минжээр зах хийх;* **минжин сэрвэ** ургамал (нэгэн зүйл шар цэцэг, эмнэлэгт хэрэглэдэг); **минжин нагва** ургамал (минжин сэрвийн нэгэн зүйл, эмнэлэгт хэрэглэнэ).

МИНИЙ нэгдүгээр биеийн төлөөний үг; *миний дүү; миний юм;* **миний бие** бичиг (би).

МИНИЙМХИЙЛЭХ минийх гэж баримтлах.

МИНИЙХ нэгдүгээр биед хамаадуулах үг; *өөрийнхөө номыг аваад, минийхийг үлдээ! энэ дээл минийх мөн байна.*

МИНУТ 1. нэг цагийг 60 хуваасны нэг хэм буюу жаран секунд; *таван минутийн дотор яваад ирэв;* 2. өнцөг ба нумны хэмжүүрийн нэгж; градусыг 60 хуваасны нэг.

МИНЧГЭР хөөнгөрч чинэсэн, чинэж улаан хүрэн болсон нь; *минчгэр нүүртэй.*

МИНЧИЙЛГЭХ минчийхийн үйлдүүлэх хэв, минчийхэд хүргүүлэх.

МИНЧИЙХ минчгэр болох; *нүүр ам минчийх.*

МИНЧРЭХ мэнэрэх, чилэх; *гар хөл минчрээд байна.*

МИНЬ нэгдүгээр биед хамаадуулах үг; *хүү минь ирэв; морь минь эцэв; ном минь байв; чи минь яав?*

МИРЭЭЛЭХ эрээлэх; **эрээлэх мирээлэх** хорш.;

МИРЭЭН эрээн; **эрээн мирээн** хорш.; *ханын сонинг эрээн мирээн болгож будаад ямар хэрэг байна даа!* **мирээн гургуул** амьтан (уулын тахиатай адил болоод хөөе бяцхан, ар шар, омруу улаан, хүзүү ногоон нэг зүйл гургуул); **мирээн удвал цэцэг** ургамал (иш улаан бөгөөд үерхэг, анар цэцэг мэт хэлтэс нь давхарласан, өнгө ногоовтор, тоорцог шар нэг зүйл удвал цэцэг).

МИС ургамал янз бөөрөнхийхөн болоод нарийхан, амт гашуувтар нэгэн зүйл жимс.

МИЧ амьтан самжийн адил болоод том, гар нь урт, дүүжлэн авирахдаа чадамгай, нас мань урт, өнгө зүйл бүр бий, орилох дуудах

дуу нь маш уяралтай, ойд сүрэглэж оршдог, бие бүтцээр хүнд хамгийн ойр, хөхөөр бойжигч амьтан; 2. Дорно зүгийн зурхайн ёсны 12 жилийн есдүгээр; *мичин жил; мичин цаг.*

МИЧИД зурхай сарны зурхайн ёсны хорин найман одны нэг.

МИШГЭЛЗЭХ инээмсэглэх байдал гаргах.

МИШИЛ I мэшил,

МИШИЛ II нэг зүйл сэлэм; *мишил сэлэм.*

МИШИЛЗЭХ инээмсэглэх.

МИШЭЭЛГЭХ мишээхийн үйлдүүлэх хэв, мишээхэд хүргүүлэх.

МИШЭЭХ инээхийн хүндэтгэл.

МОВОР ус нь ноорхой барс.

МОВГО: **мовго жимс** ургамал дулаан орны уул завт судалсан өндөр модонд ургадаг, нанхиад арүр мэт болоод хатуухан нэг зүйл жимс.

МОВЬ: **мовь цэцэг** ургамал өндөр иштэй, модны шавдлын навчтай адил навчтай, хавар цэцэглэдэг, өнгө улаан хүрэн хоёр зүйл байдаг, бийрийн хушуу мэт цоморлигтой нэг зүйл цэцэг.

МОГЖИЙХ идсэн юм зохихгүй дотор аягүй болох; *дотор могжийх.*

МОГЗГОР богино, тагдгар.

МОГЗОЙХ мэгзгор болох.

МОГОЙ амьтан хэвлээр явагчдын баг, бие нарийн урт, хөлгүй, хайрстай, ихэнх могойн шүдэнд хор бий, урт хорхой ч гэнэ; *могой биетэй, модон хумстай, хоёр гартай, нэг хөлтэй* оньсго; *могой алахад мод нэмэргүй* зүйр; *могой мөрөө танихгүй, хүн биеэ мэдэхгүй* зүйр; **могой жил** (могой тохиолдсон жил); **могой сар** (могой эзэлсэн сар); **могой өдөр** (могой эзэлсэн өдөр); **могой цаг** (могой эзэлсэн цаг): **хорт могой** (хор боловсруулах булчирхай бүхий могой); **аврага могой** (халуун оронд орших том могой, хоргүй боловч амьтан барьж иднэ); **могой эрэлж** амьтан (цагаан ямаа зарамтай адил болоод хавтгай толгойтой нэг зүйл загас); **могой загас** амьган (мөрөн голд төрнө, хэлбэр могойн адил, хайрсгүй, шар цагаан хоёр зүйл бий); **могой жарс** амьтан (мөрөн голд төрнө, могой загастай адил болоод охор, толгой шовхгор, хайрсгүй нэгэн зүйл загас); **могой бялзуухай** амьтан (хүзүүний янз могойтой адил, хөл урт нэг зүйл бялзуухай); **могой идрээ** ургамал (хээр ургадаг, идэр нооронд адилхан болоод навчиндаа хөрөө мэт соёотой, амт гашуун нэгэн зүйл идэшний ногоо); **могойн зүрхэн зандан** ургамал (өнгө харавтар улаан, үнэр сайхан нэг зүйл зандан); **могой яр** (биеийг ороосон нэгэн зурвас улаавтар мөхлөг яр): **могойн идээ** (нэгэн зүйл ургамал); **могойн ичээ** (могой олноороо хуран нүхэнд орж ичсэн газар): **могойн чуулган** (могой ичээндээ орохоор олноороо цугларсан газар); **могойн зулбадас** (могойн гуужиж гээсэн хальс);

МОГОЙРХОГ могой элбэгтэй.

МОГОЙРХУУ 1. могойтой төсөөтэй; 2. могой элбэгтэй.

МОГОЙЧ: **могойч хулгана** амьтан урт шовх хушуутай, улаан сүүлтэй, могой иддэг, нэгэн зүйл хулгана, үүний шээс нь могойн хорыг арилгахад маш сайн гэдэг.

МОГОЛЦОГ 1. хүвэр мод мэт хэлбэртэй юм; *моголцог төмөр; моголцог шийдэм;* 2. гонзгойвтор бөөрөнхий.

МОГОТОЙХ моготор болох.

МОГОТОР I мухар, эвэргүй; *моготор үнээ;* **моготор мод** (мухар үзүүртэй мод).

МОГОТОР II хэдэр огцом зантай; *моготор хүн.*

МОГОТОРДОХ хэтэрхий моготор болох.

МОГОТОРЛОХ моготор болгох.

МОГЦГОР богино, могзгор.

МОГЦОЙХ могзгор болох.

МОГЬСОХ хий бөглөрөн зангирч амьсгал авахад дотор өвдөх мэт буюу хүчингэдсэнээс болж дотор өвдөх.

МОД (ОН) I 1. хатуу иштэй олон наст ургамал, ишнээс салаа мөчир гарч модны саглагар орой болно; *модтой өндөр уул нь, монгол газрын чимэг;* **ой мод** (уулын мод); **зуун мод** (тасархай хэсэгхэн мод); **мод бэлтгэл** (модыг ямар нэгэн зүйлд хэрэглэхээр зэхэх); **яс мод** (юмны хүрээ хэрээ болох зүйл; *байшингийн яс мод; цонхны яс мод; гэрийн яс мод);* **гэрийн мод** (тооно, унь, хана, хаалга); **байшингийн мод** (байшин барилгын бүх модны зүйл); **эмээлийн мод** (эмээлийн яс мод); **мод оглох** (ургаа модыг хөрөөдөж унагаах); **модон эдлэл** (модоор хийсэн эдлэл хэрэглэлийн зүйл; *модон байшин; модон аяга; модон савх; модон хувин; модон гадас);* **модон хөлт** (гутлын уланд уртхан мод залган явж наадах тоглоом); **модон морь** (а. биеийн тамирын харайж сургуулилах хэрэгсэл; б. морины хий-

мэл толгой сүүлийг тусгай суурьд уяж, **ваадан буулгаж** сүүжинд уяж морилсон **дүрмээр наадах**); **модны дурс** (модны холтос); **модны өд** (модны холтосны доторхи хатуу нягт зүйл); **модны тасаг** (модон эдлэл хийх тасаг); **модон завод** (модон эдлэл хийх завод); **модны мужаан** (модны ажилд мэрэгжилтэй хүн); **модны нохой** а м ь т а н (модхой); **модны согсор** у р г а м а л (өвөл аливаа модонд тогтнож ургана, өнгө хөх, урт хавтгай навчтай, улаан үртэй нэг зүйл ургамал, чанаж үхэрт идүүлэхэд сайн гэдэг); **модны чийрмаа цэцэг** у р г а м а л (модон иштэй, сийрэг навчтай, янз лянхуа цэцгийн адил бөгөөд үнэр маш их, тооргоцог шар, дөрвөн сард цэцэглэнэ, үрлэхгүй нэгэн зүйл цэцэг); **модон бадам** у р г а м а л (хээр бут бутаар ургадаг, цайвар ногоон өнгөтэй, хэлтэс нь ес, нэг салаанаас нэжгээд цэцэглэж балчингаас навч гарна, эрхэм чийрмаа цэцгийн адил үнэртэй нэг зүйл цэцэг); **навчит мод** (шүлмүүст модноос ялгавартай навч бүхий мод); **шүлмүүст мод** (навчит модноос ялгавартай шүлмүүс бүхий мод); **бут мод** (бут бутаар ургах мод); **хар мод** (харгай); **нарс мод** (боргоцой бүхий шүлмүүст мод); **самрын мод** (хуш); **модны шавтал** (илжгэн чих); **модоо барих** (хөрөнгө юмаа барж хооорох; *морио унаж, модоо барих);* **мод толгой** (соруулгүй гаанс); 2. түлээ; *модонд явах; мод кублэх;* **мод хөрөөд!** (хөрөөдүүлэх мод байна уу гэж дуудах аялга); **мод хагалах** (модыг цуучин жижиглэх, түлээ хагалах ч гэдэг); **мод хөдөөдөх** (модыг хэрчим болгон огтлох).

МОД II метр; *таван мод торго авав.*

МОД III уртын хэмжээ; 1,06 километртэй тэнцүү; *дөчин таван мод газар.*

МОД IV даалуу хөзөр зэрэг тоглоомын нэг ширхэг; *чи хэдэн модтой вэ? чамд мод ирдэггүй юу? над ердөө мод ирэхгүй болжээ.*

МОДЕЛЬ маяг, загвар, хэв.

МОДЖИХ модтой болох.

МОДЖУУЛАХ моджихын үйлдүүлэх хэв, модтой болгох.

МОДЛОХ эд бараа, газрыг хэмжээ модоор хэмжих.

МОДОРХОГ 1. мод ихтэй; *модорхог газар;* 2. мод мэт, модтой төстэй.

МОДОРХУУ 1. мод ихтэй; 2. мод мэт.

МОДОС модны нягт хатуу хэсэг.

МОДОЧ: модоч уран мужаан, модны үйлдвэрт чадамгай хүн.

МОДРОХ мод шиг болох; *модорсон ногоо.*

МОДРУУ 1. малын идээд үлсэн өвсний язгуур; 2. харгана мэтийн жижиг мод.

МОДТОЙ мод бий, мод ихтэй.

МОДХОЙ а м ь т а н нохойтой адил, өнгө хар, арьс нь дэвсвэл хэвэл дүүрэх өвчин арилна, модны нохой ч гэнэ.

МОДЧИН мод огтлох ажлын хүн.

МОЙЛ (ОН) монсны жимсгэнэ; *мойлон хар нуд.*

МОЙНОГ хурууны булцруутсан, тахир, мохир; *мойног хуруу.*

МОЙНОГРОХ мойног болох.

МОЙНОХ мойногрох; *хуруу мойногерох.*

МОЛГОР мөр бүхий юм элж мөлгөр болсон нь.

МОЛЕКУЛ химийнхээ шинж чанарыг үл алдах бодисын хамгийн жижиг хэсэг; *молекулын жин.*

МОЛМОЛЗОХ мэлмэлзэх.

МОЛОР болор; *морины толгойн чинээ молор эрдэнэ, хонины толгойн чинээ ховор эрдэнэ* з ү й р.

МОЛТОГЧИН а м ь т а н нэг төрлийн туулай.

МОЛХИ болхи бүдүүлэг, дорой буурай, тэнэгдүү.

МОЛЦОГ 1. зарим ямаа, хонь, гөрөөс мэтийн адгуус амьтны хүзүүнд унжин явах бөөрөнхий годгор зүйл; 2. х у у ч и р с а н хазаарын сагалдарга, хөмөлдрөгт унжуулсан чимэг.

МОЛЦОГЛОХ юмнаас молцог мэт зүүгдэн тогтох; *молцоглон унжсан усан үзэм.*

МОЛЦОГЛУУЛАХ молцоглохын үйлдүүлэх хэв.

МОЛЦОГТОХ молцоглон тогтох.

МОМИН номин чулуу.

МОНГИНОХ моншрох, сандчих.

МОНГОЛ 1. Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Өвөр монголын өөртөө засах орны хүн амын хэсэг; *Монгол Ардын Хувьсгалт Нам; Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл; Монгол Ардын хувьсгалт цэрэг; Монгол-Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэг; Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэг;* ***баруун монгол; зүүн монгол; өвөр монгол.***

Он онд идээшиж олон онд дассан нутаг,
Одоогийн шинэ монголын улаан туг бүрхсэн орон,
Энэ бол миний төрсөн нутаг,
Монголын сайхан орон. (Д. Нацагдорж).

монгол хүн зориготой, молор эрдэнэ үнэтэй үй р; *монгол хүн морио магтана, мужаан хүн хөрөөгөө магтана* з үй р; 2. *монгол дуу; монгол эмээл; монгол дээл; монгол гутал; монгол гэр;* **Монгол хэл** (Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Өвөр монгол, Буриад АССР болон Ойрдуудын хэл); **Монгол үсэг** (Уйгаржин монгол, дөрвөлжин, тод, соёмбо, шинэ үсэг); **Уйгаржин монгол бичиг** (эрт цагт Уйгаруудаас уламжлан авсан бичиг, хуучин монгол бичиг ч гэнэ); **тод монгол бичиг** (Ойрдын Зая Бандид гэгчийн 1648 онд зохиосон бичиг): **шинэ монгол бичиг** (Кириллийн үсгээс уламжлан авсан бичиг, шинэ үсэг ч гэнэ); **монгол бүрээ** (дунд нь мод, захад нь гууль тавьж хийсэн урт бүрээ); **монгол адуу** (эрт дээр цагаас гаралтай, талын адуу, бие жижиг, хүч чадал их, тэсвэртэй, жилийн дөрвөн улиралд **билчээрээр** амьдрана); **монгол архи** (сүү **исгэж нэрдэг** архи); **монгол далан хэлт** а м ь т а н (янз далан хэлт чогчготой адилхан болоод жигүүрийн дотор үе үе цагаан өрөвлөг бүхий нэг зүйл бялзуухай); **монгол амуу** у р г а м а л (нэгэн зүйлийн тариа, мөхлөг нь улаан хоногоос томхон, эрт боловсорно); **монгол өвс** у р г а м а л (цагаалжийн төрлийн нэг зүйл өвс); **монгол цай** у р г а м а л (хөвөн оройт, сөд зэрэг цайны оронд уудаг өвсний зүйлийн нийт нэр).

МОНГОЛЖИХ гадаадын хүн, монголын хэл сурталд сурамгай чадамгай болох.

МОНГОЛЖУУ монголжсон, монгол байдалгай.

МОНГОЛЖУУЛАХ монголжихын үйлдүүлэх хэв, монголын байдалтай болгох.

МОНГОЛОРХОГ монгол шинж байдалтай.

МОНГОЛОРХУУ монгол байдалтай.

МОНГОЛЧ 1. монголыг судлагч; ***монголч эрдэмтэн;*** 2. монгол бичиг сайн мэддэг; *талийгаач минь монголч, төвдөч хүн байсан юм.*

МОНГОЛЧЛОХ монгол хэлэн дээр хөрвүүлэх, монгол хэлэнд орчуулах.

МОНГОЛЧЛУУЛАХ монголчлохын үйлдүүлэх хэв.

МОНГОЛЧУУД монгол олон аймгууд.

МОНГОЛШИХ монголын шинжтэй болох.

МОНДГОР бяцхан бондгор овгор.

МОНДОЛГҮЙ ховор биш, элбэгхэн юм.

МОНДОХГҮЙ 1. элбэг дэлбэг байдаг юм; 2. мохошгүй.

МОНДОШГҮЙ овоо ихээхэн, бишгүйдээ.

МОНЖУУ мангуу, дүйнгэ.

МОНЖУУН моншин, мангууг зайлуулах үг; *чи яасан монжуун юм бэ!.*

МОНОПОЛИ I 1. ямар нэг зүйлийг үйлдвэрлэх буюу худалдах онц эрх мөн түүнчлэн ямар нэг зүйлийг ганцаар онцгой эдлэх хэрэглэх; *улсын монополи; гадаад худалдааны монополи; монополи эрх;* 2. илүү хонжоо олох зорилгоор үйлдвэр ба худалдааны онцгой эрхийг шүүрэн булаасан капиталист том нэгдэл.

МОНОПОЛИ II нэгэн зүйл цагаан архи.

МОНОПОЛИЧЛОХ бусдын эрхийг булаан эзэрхэх.

МОНОПОЛИЧЛУУЛАХ 1. монополичлохын үйлдүүлэх хэв; 2. монополичлогдох.

МОНОС у р г а м а л мойл ургадаг анхилмал цагаан цэцэгтэй мод; *монос модонд ургасан мойл жимсээ түүцгээе.*

МОНТАЖ угсарлага, эвлүүлэг, нийлүүлэг; *барилгын монтаж.*

МОНТАЖЛАХ монтаж хийх; *зураг монтажлах.*

МОНТГОР болцгор, том, монхор.

МОНТЁР харилцаа холбоо, цахилгаан хэрэглэлийг залгах буюу сэлбэн засах мэрэгжилтэй хүн; *цахилгааны монтёр; утасны монтёр.*

МОНТОЙЛГОХ монтойхын үйлдүүлэх хэв, монтгор болгох.

МОНТОЙХ монтгор болох.

МОНТООХОЙ а м ь т а н мөрөн голд төрнө, гултай адил, нуруу моголцог, нарийн хайрстай нэгэн зүйл загас.

МОНХГОНОХ монхгор юмны монхго монхго хөдлөх.

МОНХГОР монхор, монхордуу.

МОНХГОРДУУ арай монхгор, нилээд монхгор.

МОНХГОРХОН баахан монхгор.

МОНХОЙЛГОХ монхойхын үйлдүүлэх хэв, монхор болгох.

МОНХОЙХ монхор монхгор болох.

МОНХОЛЗОХ монхор юмны монхос монхос хөдлөх.

МОНХОЛЗУУЛАХ монхолзохын үйлдүүлэх хэв.

МОНХОР хамар өндөр бөгөөд бөгтрөгтэй; *монхор хамар.*

МОНХОРДУУ арай монхор, нилээд монхор.

МОНХОРДУУХАН арай монхордуу, нилээд монхордуу.

МОНЦГОР бонцгор.

МОНЦГОНОХ монцгор юмны монцго монцго хөдлөх.

МОНЦГОНУУЛАХ монцгонохын үйлдүүлэх хэв.

МОНЦОГ 1. молцог; 2. шувууны толгой дахь чандар цацаг.

МОНЦОЙХ монцгор болох.

МОНЦОЛЗОХ монцгор юмны монцос монцос хөдлөх.

МОНЦОЛЗУУЛАХ монцолзохын үйлдүүлэх хэв.

МОНШИГНОХ моншин байдал гаргах.

МОНШИН ухаан муутай, мангуу, тэнэг.

МОНШРОХ моншин болох.

МООВИН: **моовин цаас** тутрагын хэвгээр хийсэн цаас.

МОРАЛЬ зан суртахуун, хэв заншил; **зан мораль** х о р ш..

МОРДОХ 1. юман дээр унах, зайдлах; *мориндоо мордон ухасхийв; хүзүүн дээр мордох; хашаан дээр мордох;* 2. ш и л ж с э н алс юманд хөдлөх; *Москва орохоор мордов;* **мордохын хазгай** (үйл явдлын эхнээсээ буруудах нь).

МОРДУУЛАХ мордохын үйлдүүлэх хэв; *цэргэг мордуулах.*

МОРИГҮЙ 1. унаагүй; 2. азгүй.

МОРИЛОХ 1. морь унах; 2. явахын хүндэтгэл; *морилон орно уу; та дээшээ морил.*

МОРИЛУУЛАХ морилохын үйлдүүлэх хэв.

МОРИРХОГ морьтойдоо оморхдог.

МОРИРХОХ морь унасандаа оморхох бахархах.

МОРИРХУУ морирхог, морь голдуу.

МОРИУ 1. шудрагагүй, тэрс, ханигүй; 2. эелдэггүй, зүй бус; 3. сарниу; **мориу сариу**

МОРЧГОР үл таашаасан байдал нүүрэнд тодрох илрэл х о р ш..

МОРЧИЙЛГОХ морчийхын үйлдүүлэх хэв, морчгор болгох.

МОРЧИЙХ морчгор болох.

МОРЬ (МОРИН) 1. адгуус, засч агталсан адуу; *зээрд морь; хурдан морь; жороо морь; эмнэг морь; тэрэгний морь; морьтой хүн; мориор явах; наадмын морь; морь уу гүү юү? сайн морь;* **морь мал, агт морь** х о р ш.; *морины сайныг унан байж мэд, хүний сайныг ханилан байж мэд* х у у ч; *эр хүн зорьсондоо, эр морь харайсандаа* х у у ч.; *морины жороо махаа барна, хүний жороо хүнсээ барна* з ү й р; **морь уях** (а. уралдах морийг сойх; б. бие засах): **морь сойх** (уралдааны морийг хагсааж биеий нь живхнүүлэх); **морь тавих** (а. уралдах газраас морь эхлэн гарах; б. унаа морийг идэшлүүлэхээр тавих буюу ижилд нь нийлүүлэх; *би бор морио тавьж хонох юм байгаа;* в. өөрийн морийг буцдын адуунд нийлүүлж адуулгах); **морь харах** (бие засах); **морь гарах** (уралдааны морьд уралдах газар руугаа явах); **морь уралдах** (морины хурдыг тэмцэх); **морь тарлах** (морь үсэргэх); **морь үсэргэх** (уралдах морийг довтолгон дасгаж сургах); **морь хөлслөх** (морьдыг давхиулан хөлсийг гаргах); **морь барих** (а. уралдсан морийг барианы газар ирэхэд нь тосч барих; б. тавьсан морийг барьж авах); **морин өртөө** (мориор алба залгуулах үүрэг гүйцэтгэгч газар); **морин тойруулга** (уралдааны морьд тойрон уралдах газар); **морины уяа** (а. хурдны морь уях ажиллагаа; *энэ морины уяа нь таарч байна;* б. морь уях шон мод); **морин тэрэг** (моринд хөллөх тэрэг), **морь хөтлөгч** (морьт цэргийн дарга нарын морийг харж адуулах хүн); **морин шил** (том шилэн лонх); **морин тармуур** (морь оруулан хөллөж өвс тармах тармуур); **морин цэрэг** (морьт цэрэг): **морин дивиз** (морьт дивиз); **морин хуур** (монгол үндэсний нэгэн зүйл хөгжмийн зэвсэг); **морин хийл** (чавхдаст хөгжмийн нэг зэвсэг); **морин**

дээгүүр (хурдан, яаруу); **морин дэл дээгүүр** (хурдлан, яаравчлан); **морин зээргэнэ ургамал** (цагаан буюу шар цэцэгтэй балт, анхилмал өвс); **морин улаагана ургамал (цагаан** цэцэгтэй, гашуун улаан жимсгэнэтэй бут); **морин агь ургамал** (агийн төрлийн нэгэн зүйл өвс); **морин шарилж ургамал** (жижиг хонгорцог цэцэгтэй, гашуун амттай, сэнгэнэсэн үнэртэй ногоо); **морин шаваг ургамал** (шавгийн төрлийн нэг зүйл том бут); **морин хад ургамал** (исгэлэндүү амттай, томхон жимсгэнэтэй, өргөстэй бут); **морин хулгана амьтан** (хээр талд орших нэг зүйл хулгана, билчээрт хорхой); **морин хараацай амьтан** (хараацайтай адил болоод маш том нэг зүйлийн шувуу, жихүүн газар оршиж чадна); **морин мэлхий амьган** (мэлхийтэй адил болоод бие нь нарийхан, үүгүй, махыг иддэг); **морин хэдгэнэ амьтан** (торхи зөгийтэй адил болоод бие нь үстсэн, морины ам хамар руу ордог нэгэн зүйл ялаа); **морин зөгий амьтан** (нарийвтар биетэй, шар хар эрээн зүстэй, хатгавал хортой нэгэн зүйл ялаа); **морин хүрэлзгэнэ амьтан** (үхэр хүрэлзгэнээс том, хар өнгөтэй нэг зүйл хүрэлзгэнэ); **морин шоргоолж амьтан** (том хар шоргоолж); **морин шилүүс** (нас гүйцсэн том шилүүс); **морин хонх** (дүүжлүүр том хонх); **морий нь унуулах** (өвчнийг хүндрэхийг түргэтгэх): 2. дорно зүгийн зурхайн ёсны арван хоёр жилийн долдугаар; *морин жил;* 3. шатрын нэг бод; *мориор нүүх; өрөөлтэй морины өшгөлөн шаг;* 4. шагааны хавиргаар босгосон нэгэн тал; *морь босгох).*

МОРЬСОГ морь унах дур сонирхол ихтэй, морь унамтгай.

МОРЬТ 1. морь бий; *морьт цэрэг; их бууны морьт хороо;* 2. аз сайтай.

МОРЬТОЙ 1. морь унасан, морь бүхий; 2. аз сайтай; 3. морь эзэлсэн жил төрсөн.

МОТОР дотоод оньсон хөдөлгүүр; *онгоцны мотор; машины мотор; мотор нь цохиотой байна.*

МОТОРТ мотор бий; *моторт дугуй.*

МОТОРЧ мотор хийдэг засварладаг хүн.

МОТОЦИКЛ дотоод оньсон хөдөлгүүр бүхий хүнд жинтэй дугуй; *мотоциклоор явах; мотоциклын уралдаан.*

МОХДОГ мохоо, ухаан муутай.

МОХЛИГ: бодох мохлиг сампин.

МОХОО 1. иргүй, даац муутай; *мохоо хутга;* 2. *шилжсэн* ухаан муу, сэргэлэн биш; *мохоо ухаантай;* 3. хашин хойрго.

МОХООДОХ хэтэрхий мохоо болох.

МОХООЛГОХ 1. мохоохын үйлдүүлэх хэв; 2. мохоогдох.

МОХООРОХ мохоо болох; *зориг нь мохоорох.*

МОХООХ 1. мохохын үйлдүүлэх хэв; 2. шилжсэн хэлэх үггүй болгох; *дахин үг өгүүлэл гаргахгүй болтол нь мохоов.*

МОХОХ 1. халирах, шантрах; *зориг мохох; үг мохох;* 2. ир нь муудах; *үзүүр нь мохох; ир нь мохох.*

МОХОШГҮЙ мохохуяа бэрх, шантаршгүй, үл мохох; *мохошгүй зоригт.*

МОХРОЛ мохуул, мухардал.

МОХУУЛ I зарим багаж зэвсгийн аагны уг этгээд; *хутганы мохуул; бахины мохуул.*

МОХУУЛ II үйл хэргийн төгсгөл дуусвар; *хэргийн мохуул; мохуулыг үзэх.*

МОХУУЛГҮЙ дуусгал төгсгөлгүй, хязгааргүй, хэмжээлшгүй.

МӨГӨӨРС (ӨН) I бие махбодын хатуу бөгөөд уян холбох нэхмэлээр бүтсэн хэсэг ба үеийн бүрхүүл; *мөгөөрст нимгэн хоолойтны дуу хүрээгүй газар; далны мөгөөрс;* **мөгөөрсөн хоолой** (амьсгалын хоолой).

МӨГӨӨРС II нялх хүүхдийн шүд ургах газар гарсан шар яр.

МӨГӨӨРСТӨХ нялх хүүхдийн шүд ургах газар юм гарч хөхөө шимж чадахгүй болох.

МӨГӨӨС мөгөөрс.

МӨГҮҮ үүд, цонх, ширээ зэргийн юмны ирмэгт хөвөөлсөн янз мод; *цонхны мөгүү; ширээний мөгүү.*

МӨГЦ I мөрөг загасны зулзага.

МӨГЦ II бэрээмэг гэдэг өвсний будаг оруулсан тос.

МӨД даруй, удахгүй, төд; *мөд ирнэ; мөд дулаарна.*

МӨДӨД мөд.

МӨДХӨН даруйхан, төдхөн; *гараад холдоогүй; мөдхөн ирнэ.*

МӨЛГӨР I ирмэг иргүй; *мөлгөр хутга;* **мөлгөр чих** (дэлбэн нь ирмэггүй).

МӨЛГӨР II гилгэр, мөлчгөр; *мөлгөр хад; мөлгөр шил.*

МӨЛЖИГДӨХ мөлжихийн үйлдэгдэх хэв.

МӨЛЖИГЧ мөлждөг этгээд; *мөлжигч анги.*

МӨЛЖИМТГИЙ шунахай, мөлжихдөө чадамгай; *мөлжимтгий худалдаачин.*

МӨЛЖИМХИЙ мөлжимтгий.

МӨЛЖИХ 1. яснаас махыг салган авах; *яс мөлжих;* 2. ш и л ж с э н бусдыг хохируулан ашиг үлэмж олох; *дамын худалдаачин бусдыг мөлжиж амтшичээ; нийгэм журамт нийгэмлэг бол хүн хүнээ мөлжих ёсыг үүрд устгав.*

МӨЛЖМӨЛТ 1. бусдаас хонжин ашиглаач хүн; 2. бусдад халдаж шоглох зантай хүн.

МӨЛЖӨӨР мөлжүүр.

МӨЛЖҮҮЛЭХ 1. мөлжихийн үйлдүүлэх хэв; 2. мөлжигдөх.

МӨЛЖҮҮР 1. мах идэхэд ясанд үлдсэн мөлжиж идэх махны зүйл; *мөлжүүртэй яс;* 2. өвсний хальс; 3. ш и л ж с э н цаашид шавхахад гарч ирэх хөрөнгө зөөр: **мөлжүүртэй айл** (юмтай чинээлэг айл); 4. ш и л ж с э н цааш нь шавхахад гарч ирэх сайн чанар; мөлжүүртэй хүн (мэдлэг чадал гүнзгий).

МӨЛЖҮҮРГҮЙ 1. мөлжүүр багатай, мөлжүүр муутай; 2. гоочгүй, гооч муутай; *мөлжүүргүй хүн.*

МӨЛЖҮҮРТЭЙ 1. мөлжүүр бүхий мөлжүүр ихтэй; *тоглоом тоотой нь дээр, толгой мөлжүүртэй нь дээр* х у у ч; 2. гооч сайтай, гооч ихтэй; *мөлжүүртэй айл; мөлжүүртэй гооч-той хүн.*

МӨЛИЙЛГӨХ мөлийхийн үйлдүүлэх хэв, мөлгөр болгох.

МӨЛИЙХ I мөлгөр болох, ирмэг иргүй болох; *ирмэг нь мөлийжээ; мөлийсөн иртэй хутга.*

МӨЛИЙХ II гилгэр мөлгөр болох, мөлцийх.

МӨЛИЙХ III их усны түвшин алгуур урсах; *Сэлэнгэ мөрөн мөлийн урсаж байна.*

МӨЛМӨЛЗӨХ мөлмөлзөх.

МӨЛӨГНӨХ мөлгөр юмны хөдлөх, сэрэгдэх; *загас мөлөгнөөд баригдахгүй байна.*

МӨЛӨЛЗӨХ мөлгөр юмны мөлс мөлс хийх.

МӨЛӨХ I юмны салаа мөчир зэргийг элэн авах; *модны мөчрийг үзүүрээс нь мөлөх хэрэгтэй;* **элэх мөлөх** х о р ш..

МӨЛӨХ II бусдыг далдуур хөнөөн дийлэх; *түүнийг мөлж дөнгөсөн байх аа.*

МӨЛС мөс.

МӨЛТ хальт, мөчид, гүйцэд биш; **хальт мөлт** х о р ш.; *хальт мөлт үнэдэг болохын хамт; мөчид мөлт явдал.*

МӨЛТЛӨХ мултлах; *өндөр юман дээрээс унахад мөрөө мөлтөлж болно.*

МӨЛТӨРХИЙ I мултархай, мөлтөрсөн юм; *мөлтөрхий мөр.*

МӨЛТӨРХИЙ II омтгай, наагуур, хуумгай.

МӨЛТӨС арайхан, магад, дөнгөж; *ам мөлтөс дайралдав.*

МӨЛТРӨХ мулграх, мултран гарах; *мөр мөлтрөх; уяа нь мөлтрөх.*

МӨЛҮҮ (Н) мөлгөн.

МӨЛҮҮЛЭХ 1. мөлөхийн үйлдүүлэх хэв; 2. мөлөгдөх.

МӨЛҮҮН хүйтэн; *миний хөл мөлүүн болчихов; энэ өдөр мөлүүн байна.*

МӨЛҮҮХЭН нилээд мөлүүн.

МӨЛХЛӨХ 1. мөлхөх; 2. байн байн буюу олноор мөлхөх.

МӨЛХӨӨ 1. хүн амьтны мөлхдөг нь; **мөлхөө болох** (хоёр хөл дээрээ явж чадахгүй болох); 2. чонын цээрлэсэн нэр.

МӨЛХӨХ 1. хүний түрүүлгэн хандаж гар хөлөөр давшилхилан явах; *сэмхэн мөлхөж ойртон очив;* 2. амьтны хөлөө нугалж өвдөг борвиороо давшилхилан явах.

МӨЛХРҮҮЛЭХ мөлхүүлэх.

МӨЛХҮҮЛЭХ 1. мөлхөхийн үйлдүүлэх хэв; 2. бусдыг нэвширтэл жанчиж хөдөлж чадахгүй болгох.

МӨН 1. бишийн эсэргүүцэл утга, зөв; *мөн бишийг мэдэхгүй; өнөөдөр бүтэн сайн өдөр мөн; энэ миний бичиг мөн; мөн чингэх ёстой байв; мөнөөсөө мөн;* **мөн чанар** (үзэгдлийг танин мэдэхээр нээж олох, ямар нэг юмны дотоод агуулга, ахуй чанар; *марксизм-ленинизмийн хувьсгалт мөн чанар; сургаалын мөн чанар; түүний мөн чанар;* 2. бас, бас тэр; *мөн оны аравдугаар сард, мөн үед; мөн үзэгдэл; мөнхүү хэрэг; мөн түүнийг; мөн тэрийг.*

МӨНГӨ (Н) 1. цагаавтар өнгөтэй, өнгөлөг, үнэт төмөрлөг; **алт мөнгө, мөнгө төгрөг, мөнгөн санхүү** х о р ш.; *арван лан мөнгө;* 2. мөнгөлсөн юм; *мөнгөн аяга; мөнгөн хутга; мөнгөн хазаар;* 3. худалдан авах ба худалдахад өртгийн хэмжүүр болох төмөрлөг ба цаасан тэмдэгт; *нэгтийн мөнгө; аравтын мөнгө; чамд мөнгө байна уу?* **мөнгөн тэмдэгт** (улсаас өөрийн орны дотор зарцуулах, тусгай маягаар хэвлэж гаргасан цаас зоос); **мөнгөн ембүү** (тусгай хэвт цутгасан мөнгө; *хэдэн лангийн ембүү вэ?);* **мөнгөн төгрөг** (мөнгөөр хийсэн мөнгөн тэмдэгт): **гулууз мөнгө** (тусгай хэмжээгээр гулдан болгон цутгасан мөнгө); **цалин мөнгө** (дээд зэргийн зөөлөн цагаан мөнгө); **мөнгөн хөрөнгө** улсын үнэт хатуу хөрөнгө); **мөнгөн сан** (улсын мөнгө хадгалах газар); **мөнгөн тусламж** (мөнгөөр олгох тусламж); **мөнгөн шагнал** (мөнгөөр өгөх шагнал); **мөнгөн ханш** (мөнгөний үнэ); **мөнгөний ханш буурах** (аливаа оронд цаасан мөнгөний эргэлтийн хэмжээ асар их болсноос шалтгаалан мөнгөний үнэ буурах); **мөнгөний эргэлт** (мөнгөний байнгын гүйлгээ); **мөнгөн орлого** (аливаа юмнаас авч байгаа мөнгө; *мөнгөн орлогын данс);* **мөнгө гуйвуулах** (мөнгийг банк, шуудан, цахилгаанаар дамжуулан илгээх); **мөнгө идэх** (улсын мөнгөн хөрөнгийг хувьдаа ашиглан жавших): **мөнгө шамших** (мөнгө идэх); **мөнгө цутгах** (хээл хахууль өгөх); **мөнгөний реформ** (улсын зүгээс мөнгөний эргэлтийг өөрчлөх шинэчлэлт); **мөнгөний нярав** (мөнгийг гардан барих хүн); **сохор улаан мөнгө ч өгөхгүй** (юу ч өгөхгүй); 3. жижиг зоос, төгрөгийн зууны нэг хувь; *далан таван мөнгө; арав мөнгөний марк; улаан мөнгө; цагаан мөнгө; задгай мөнгө;* 4. хөрөнгө, зөөр; *мөнгө их зарах; өнгө мөнгөнд дурлах; цай мөнгөөр бага айл; хөрөнгө мөнгөөр баялаг;* 5. төлбөр, хөлс, үнэ, татвар; *би энэ сарын байрны мөнгө хураалгана;* **бодын хөлийн мөнгө** (малаас авч байсан татвар); ☆ **мөнгөн гүйлс** у р г а м а л (нүцгэн үрт ургамлын маягийн мод, үрий нь иднэ); **мөнгөн загас** а м ь т а н (ус хөлдсөн хойно гол нуурааас олддог, махны амт маш сайн, уртаараа сөөм илүүхэн нэгэн зүйл загас); **мөнгөн цацагт** у р г а м а л (бут бутаар ургадаг, ялам модны навчтай адилхан навчтай, цагаан өнгөтэй, найман хэлтэстэй, тоорцгоос нь нарийн цагаан түрүү ургадаг нэгэн зүйл цэцэг); **мөнгөн уруул** (морины хамрын үзүүрт бяцхан цагаан арьс махтай); **мөнгөн ус** (химийн үндсэн махбод, мөнгөн цагаан өнгөтэй, шингэн төмөрлөг).

МӨНГӨГҮЙ хөрөнгө чинээгүй, ядуу зүдүү.

МӨНГӨЛӨХ юмыг мөнгөөр өнгөлөх, бүрэх; *аяга мөнгөлөх.*

МӨНГӨЛҮҮЛЭХ мөнгөлөхийн үйлдүүлэх хэв.

МӨНГӨТЭЙ баялаг чинээлэг, амьдрал ахуй сайтай.

МӨНДИЙЛӨХ аливаа юмыг бөөрөнхий хэлбэртэй болгох.

МӨНДӨЛ тарвага, бозлогийн зулзага; *тарваганы мөндөл.*

МӨНДӨЛЛӨХ тарваганы мөндөл төрүүлэх.

МӨНДӨР жижигхэн бөөрөнхий мөсөөр орох хур, агаарын тунадас; *мөндөр цохих; мөндөр орох; мөндөрт дайрагдах;* **мөндөр буулгах** ш и л ж с э н (зай завсаргүй шидэх, чулуудах, явуулах зэрэг; *цаасаар бичгээр мөндөр буулгах).*

МӨНӨӨ сая; **мөнөө сая** х о р ш.

МӨНӨӨХӨН саяхан нь; *мөнөөхөн манай нутагт цас үлэмжхэн орж, зарим аж ахуй малаа билчээхгүй хашаа хороондоо тэжээж байна.*

МӨНХ юмны цаг үргэлжид хувирамтгай биш, бат бэх орших чанар; *Монгол-Зөвлөлтийн ард түмний мөнхийн найрамдал; Сүхбаатарын байгуулсан үйл хэрэг хэзээд мөнх! мөнх ногоон ургамал; эд хөврэг, эзэн мөнх* е р ө ө л; **мөнх цэвдэг** (газрын хөрсөн дор ба дээр байх үргэлждийн хөлдүү; *бүх дэлхийн хуурай газрын хорин таван хувий нь ил мөнх цэвдэг эзэлнэ*); **мөнх зул** (үргэлж асах зул); **мөнх бус** (хамаг юм хэзээд өөрчлөгдөх жамтай); **мөнх бусыг үзүүлэх** (нас барах); **мөнх тэнгэр** (монголчууд бөөгийн мөргөлтэй байхад шүтэж байсан тэнгэр; *мөнх тэнгэрийн хүчинд);* **мөнхийн ус** (үлгэр домогт гардаг ус, уувал мөнхжинө гэдэг); **мөнх харгана** у р г а м а л (навч нь ганддаггүй нэгэн зүйл харгана); **мөнх өвс** (өлзийт өвс); **мөнх нугас** а м ь т а н (мөрөн голд төрдөг, өнгө хар, толгой том, хайрстай нэгэн зүйл загас).

МӨНХЖИХ мөнх болох, үүрд, үргэлжид тогтнон орших; *алтан нарны туяанд энхжин төрсөн орон, мөнгөн сарны гэрэлд мөнхжин гялалзсан газар* (Д. Нацагдорж).

МӨНХЖҮҮЛЭХ мөнхжихийн үйлдүүлэх хэв, мөнх болгох.

МӨНХЛӨХ мөнхжүүлэх, мөнх болгох.

МӨНХЛҮҮЛЭХ мөнхдөхийн үйлдүүлэх хэв, мөнх болгуулах.

МӨНХРӨӨ ургамал зэлийн угт ургадаг, нэг буурцагт хоёр зуу илүү үртэй, амт нь тууламайн бөөр мэт нэг зүйл жимс.

МӨНХРӨХ мөнхжих, мөнх болох.

МӨНХРҮҮЛЭХ мөнхрөхийн үйлдүүлэх хэв, мөнх болгох.

МӨӨГ ургамал цэцэг, үргүй, спороор урждэг, доод төрлийн ургамал; *цагаан мөөг; хар мөөг; мөөг түүх;* **мөөгний хүрээ** (мөөг ургадаг дугуй буйр).

МӨӨГӨНЦӨР ургамлын бичил организм.

МӨӨГТ амьтан хулсан модны ятуу, мах нь мөөг мэт амттай.

МӨӨР дугуй юмны хүрээ; *дугуйны мөөр; мөөртэй шал.*

МӨӨРЛӨХ мөөр хийх, мөөртэй болгох.

МӨӨРӨЛДӨХ олуул мөөрөх, харилцан мөөрөх; *үхэр мөөрөлдөж, хонь ямаа майлалдав.*

МӨӨРС мөгөөрс.

МӨӨРСТӨХ мөгөөрстөх.

МӨӨРӨХ үхрийн дуугарах дуу; *үнээ мөөрч байна.*

МӨӨРҮҮЛЭХ мөөрөхийн үйлдүүлэх хэв.

МӨР I 1. юмны ором; *хүний мөр; шувууны мөр; чоныи мөр; мөр гаргах;* **ул мөр** хорш.; **мөрөө баллах** (аливаа хэргийн гэрч баримтыг устгах); *цаасан дээр нэртэй, цасан дээр мөртэй* зүйр; 2. зам; **зам мөр** хорш.; *мөрөө алдах; машины мөр;* **мөрөөрөө явах** (а. урьдын явсан замаараа явах; б. бусдад гэм халгүй явах); **нэг мөр болгох** (мөрдөж явуулах нэг зарчимтай болгох); **мөрийн хөтөлбөр** (үйл явдлын агуулга зорилго; *намын мөрийн хөтөлбөр*); 3. шугам, зураас; *догол мөр; шинэ мөр; мөр алгасах; дөрвөн мөр шүлэг;* **мөр дэвшүүлэх** (ерийн шугамнаас дээш өргөж бичих); 4. эгнээ, зэрэгцээ; *гол мөр; ар мөр; хойт мөр; урт мөр.*

МӨР (ӨН) II 1. хүний дал бугалаг хоёрын уулзвар орчны газар; *мөрөн дээр нь алгадах;* **мөр зэрэгцэн явах;** *мөр зэрэгэлдээ;* **мөр зэрэгцэх** (а. тэгш явах; б. ана мана явах); 2. **нумны бариулын хоёр хажуу;** *нумны мөр.*

МӨР III ирт юмны ирийн нэгөө эгцээд; *хүрганы мөр; сэлэмний мөр; сүхний мөр.*

МӨРГӨЛ мөргөх үйлийн нэр; *эргэл мөргөл хийх; мөргөлийн газар; мөргөлийн мод.*

МӨРГӨЛДӨӨН мөргөлдөх үйлийн нэр, тэмцэлдээн; *хил дээр сүрхий мөргөлдөөн болж гэнэ.*

МӨРГӨЛДӨХ 1. мөргөхийн үйлдэлдэх хэв, эврээр бие биенйг мөргөн тулалцах; *бух мөргөлдөж байна; мөргөлдөж тоглох;* 2. шилжсэн хүний нэгэн газарт санамсаргүй тулгаран тохиолдох; *гэнэт гудамжинд мөргөлдөөд их л санд рав;* 3. тэмцэлдээн.

МӨРГӨЛДҮҮЛЭХ мөргөлдөхийн үйлдүүлэх хэв, мөргөлдөхөд хүргүүлэх.

МӨРГӨЛӨХ 1. байн байн мөргөх; 2. толгойгоор нудчих; 3. учир зүйгээ олохгүй тулгардаж яаж ч чадахгүй, тэнэж тэмтчин явах.

МӨРГӨЛЧИН мөргөл хийхээр яваа хүмүүс.

МӨРГӨМТГИЙ мөргөх дуртай, мөргөдөг зантай, мөргөмхий.

МӨРГӨМХИЙ мөргөдөг зантай, мөргөх дуртай; *мөргөмхий үхэр.*

МӨРГӨХ 1. толгойгоо ямар нэгэн юманд зориуд хүргэж ёслох; *бурханд мөргөх; газарт мөргөх; хад мөргөх;* 2. толгойгоороо ямар нэг юмыг түлхэх, сэжих, тулгарах; *хуц мөргөх; мөргөдөг үхэр;* 3. уулзах учрахаар очсон айл эзгүй тохиолдох; *би тэдний үүдийг мөргөчихөөд ирэв;* ☆ **хий мөргөх, гоц мөргөх** (бөхийн барилдаанд барилдах эсэргүүцэл бөхгүй учир хий давсанд тооцох).

МӨРГҮҮЛЭХ 1. мөргөхийн үйлдүүлэх хэв, мөргөхөд хүргүүлэх; 2. мөргөгдөх.

МӨРДЛӨГ мөрдөх үйлийн нэр; 1. мөрдөж баримтлах юм; *зохих заавраыг мөрдлөг болгох; мөрдлөг болгох зүйлийг өгөөрэй;* 2. үйл хэргийн уг учир шалтгааныг нарийлан мөшгөх; *мөрдлөг явуулах;* 3. мөрөөр нь замнах.

МӨРДӨГДӨХ мөрдөхийн үйлдэгдэх хэв, мөшгөгдөх.

МӨРДӨХ 1. юмны зам мөрөөр орон явах; *мөрдөн хөөх;* 2. шилжсэн мөрийг мөшгөн хянаж шалгах; **мөрдөн байцаах** (гэмт хэрэг эдүүлсэн явдлыг илрүүлэн гаргах); **мөрдөх мөшгөх** хорш.; 3. шилжсэн дагаж дуурнах, журамлах; *дагаж мөрдөх; мөрдөн дагаж яваа хууль дүрэм.*

МӨРДҮҮЛЭХ 1. мөрдөхийн үйлдүүлэх хэв; 2. мөрдөгдөх.

МӨРИЙ 1. мөрийцөн наадахад тавих юм; *мөрийтэй тоглоом;* 2. мэтгэлцэх, булаалдахад алдсан нь хожсондоо өгөх юм; *юугаар мөрий тавих вэ? мөрий хожих.*

МӨРИЙЦҮҮЛЭХ мөрийцөхийн үйлдүүлэх хэв, мөрий тавиулах.

МӨРИЙЦӨХ 1. мөрий тавих, алдаж хожигдвол ямар нэгэн үүрэг гүйцэтгэнэ гэж болзол тогтоох, мөрий тавьж наадах; 2. мөрий тавьж булаалдах, мэтгэлцэх.

МӨРЛӨХ I хүний мөрөөрөө юм хум өргөх, хэдрэх; *мөрлөж өргөх; мөрлөөд явах,*

МӨРЛӨХ II 1. мөрөөр орох; 2. мөр ором гаргах; 3. мөр эгнээ болж байх; *мөрлөн суух.*

МӨРЛӨХ III 1. юмны мөрөөр цохих; 2. шагаа орхиход хиеэ болон зогсох; *шагаа мөрлөх.*

МӨРЛҮҮЛЭХ мөрлөхийн үйлдүүлэх хэв.

МӨРӨВЧ 1. мөрөн дээгүүр хэдрэх оосор, халхавч; *бүсний мөрөвч; хуягийн мөрөвч,* 2. хуучирсан эхнэр хүний дээлийн мөрөнд хийх махир мод *эхнэр дээлийн мөрөвч.*

МӨРӨВЧЛӨХ юмыг мөрөндөө эгэлдрэглэх; *буу мөрөвчлөх.*

МӨРӨВЧЛҮҮЛЭХ мөрөвчлөхийн үйлдүүлэх хэв.

МӨРӨГ амьтан цэнгэг усны ясархаг загас.

МӨРӨГЛӨХ олон дахин мөргөх.

МӨРӨГЦӨГ газрын тохойрсон мөгүү эрэгцэг; **эрэгцэг мөрөгцөг** хорш..

МӨРӨГЦӨХ үхрийн толгойгоо нийлүүлэн тулж зогсох; *үхэр мөрөгцөж байна.*

МӨРӨЛДӨХ үйл ажлыг биедээ даан хүлээж авах; *мөрөлдөн хариуцах.*

МӨРӨЛСӨХ байн байн мөрлөх, дахин дахин мөрлөх.

МӨРӨЛСҮҮЛЭХ мөрөлсөхийн үйлдүүлэх хэв, мөрөлсөхөд хүргүүлэх.

МӨРӨЛТГӨХ мөрөлтөхийн үйлдүүлэх хэв, мөрөлтөхөд хүргүүлэх.

МӨРӨЛТӨХ мөрлөх, **мөрөөрөө өргөх.**

МӨРӨН далай буюу тэнгэст цутгах урсгал их гол; *Сэлэнгэ мөрөн; Ижил мөрөн;* **гол мөрөн** хорш.: **мөрний морь** амьтан (Африк тивт гол мөрөн нуурын ойр ойр модон дотор орших туурайт, хөхөөр өсөх том амьтан).

МӨРӨӨДӨЛ үлэмж хүслэн, хүсэл; **хүсэл мөрөөдөл** хорш.; *чиний мөрөөдөл болоод байлаа.*

МӨРӨӨДӨХ мартахгүй хүсэн санах; **санаж мөрөөдөх** хорш.; *даруй түргэн учрахыг хүсэн мөрөөдөв.*

МӨРӨӨДҮҮЛЭХ мөрөөдөхийн үйлдүүлэх хэв.

МӨРӨӨЛ мөрөөдөл; **мөрөөл болох** (их л мөрөөдөх).

МӨРТЛӨӨ тийм байтлаа; *өөрөө тийм мөртлөө бусдыг битгий хэл!*

МӨРТӨӨ I адилгүй, өсөд өөр; *шал мөртөө болох нь хэнд ч тодорхой биш үү.*

МӨРТӨӨ II мөртлөө.

МӨРТӨӨ III гэмгүй, хувиа сахиж явсан нь; *мөртөө явсан хүнийг хэн зэмлэх билээ; чи тоглох мөртөө тоглохгүй бусдыг битгий уруу тат! суух мөртөө суу! явах мөртөө яв!.*

МӨРЧ мөр хөөх мөшгөхдөө сайн; *мөрч нохой; мөрч амьтан.*

МӨС (ӨН) I хөлдсөн ус, хөлдүү ус; *мөсөн дээр мөнгөн аяга* оньсго; **мөсөн галав** (дэлхийн түүхэнд газрын хөрсний ихээхэн хэсэг нь мөсөнд хучаатай байсан үе); **умард мөсөн далай** (дэлхийн бөмбөрцгийн умард туйлын үлэмж их мөс); **мөсөн уул** (далайд хөвж явах мөсөн уул); **мөсөн чихэр** (мөстэй адил байдалтай хиймэл чихэр); **мөс агих** (ус хадаалан хөлдөх); **мөс нэмүүрэх** (хавар болж мөс хэврэгших); **мөс барилдах** (мөс сая гүйцэд хөлдөх); **мөс далагнах** (мөс овойж нуруутан хөлдөх); **мөс цавтах** (мөс ан гарч хагарах); **мөс тээрэмдэх** (хавар мөс урсан овоололдож харилцан харгацан тойрох); **мөс хайлах** (мөс ус болох, болгох); **мөс өрөмтөх** (ус дөнгөж өрөм мэт өнгөц хөлдөх); **мөс түгдийх** (мөс маш зузаан хөлдөж нуруутан өндөрлөж овойх); **мөс унах** (хаврын цаг, мөс хагаран хагарсаар барах).

МӨС II харвах сумны өд наах газар; *сумны мөс.*

МӨС III хүний ханилгаа чанар; *хүний мөсөөр барагтайхан.*

МӨСТӨЛ 1. мөстөх үйлийн нэр; 2. мөсөөр бүрхмэл байсан үе; *мөсдөлийн үе.*

МӨСТӨХ мөс тогтох; *гол мөсдөв.*

МӨСТҮҮЛЭХ мөстөхийн үйлдүүлэх хэв.

МӨСЧ: **мөсч хулгана** а м ь т а н эрт цагийн заан арслан.

МӨТӨГ сумны хоёр этгээдийн ир.

МӨТӨР үтэр, түргэн, одоо, бушуу.

МӨТӨРХӨН баахан түргэхэн, одоохон, бушуухан.

МӨХГӨР мэхгэр.

МӨХИЙХ мэхийх.

МӨХЛӨГ 1. үр тарианы ширхэг; *тарианы мөхлөг;* 2. өчүүхэн ширхэг, бөөрөнхий.

МӨХЛӨГТ мөхлөг бүхий юм; **мөхлөгт төрс** (нэг зүйлийн хар төрс).

МӨХӨЛ мөхөх үйлийн нэр, сөнөл.

МӨХӨӨЛ I мөхөөх үйлийн нэр. сөнөөл.

МӨХӨӨЛ II шингэн юмны хөлдсөн зайрмаг.

МӨХӨӨЛТӨХ мөхөөл тогтох, мөхөөл бий болох; *ус мөхөөлтөх.*

МӨХӨӨХ мөхөхийн үйлдүүлэх хэв, сөнөөх, бохөөх.

МӨХРҮҮ чам загасны эм.

МӨХӨС 1. дутуу, дурган, дорой, буурай; *чадал мөхөс; мөхөс ядуу;* 2. х у у ч и р с а н биеэ хөнгөмсөглөн өгүүлэхэд хэрэглэх үг; *мөхөс хүн; мөхөс миний бие; мөхөс доод.*

МӨХӨСДӨХ хэтэрхий мөхөс болох, чадал хүрэхгүй болох; *чадвар мөхөсдөв.*

МӨХӨСДҮҮЛЭХ мөхөсдөхийн үйлдүүлэх хэв, мөхөсдөхөд хүргүүлэх

МӨХӨСТӨХ мөхөс болох; *хүчин чинээ мөхөстөх; бүл мөхөстөх.*

МӨХӨСТҮҮЛЭХ мөхөстөхийн үйлдүүлэх хэв, мөхөс болгох.

МӨХӨСХӨН арай мөхөс, баахан мөхөс.

МӨХӨХ сөнөх, устах, бохөх; **сөнөх мөхөх, үхэх мөхөх** х о р ш.; *гал мөхөх; зул мөхөх; сүйрч мөхөх; буурч мөхөх.*

МӨХӨЦ мөрөг загасны зулзага.

МӨЦӨХ мөчих I

МӨЧ I цагийн хэм, нэг цагийн дөрөвний нэг, арван таван минут.

МӨЧ II 1. гар хөл, адгуус амьтны хөл; *дөрвөн мөч бадайрах;* 2. малын махны хуваарь; **нэг мөч мах** (хөл махыг хоёр хуваасны нэг); *мөч мөчөөр нь салгах;* **арван хоёр мөч** (дөрвөн хөл 8 мөч, ууц 2 мөч, сээр хүзүү тус тус нэжгээд мөч).

МӨЧИГ: **мөчиг тачиг, мөчиг хачиг** арай чарай, дөнгөн данган; *тэднийх хүүхэд олонтой болохоороо идэх уух нь мөчиг тачиг хүрч байх юм.*

МӨЧИГДӨХ I хэтэрхий мөчиг болох.

МӨЧИГДӨХ II мөчихийн үйлдэгдэх хэв.

МӨЧИД 1. *лав* биш, дутмагдуу, бат найдвартай биш; *мөчид барих; оосрын үзүүр мөчид хүрэв;* 2. ш и л ж с э н гүйцэд биш, дутуу, **омтгой; дутуу мөчид ойлгох** (дутуу ухамсарлах); **ухвар мөчид** (ухамсар муутай); **ухаан мөчид** (ухаан муутай).

МӨЧИДДӨХ 1. мөчид болох, хэтэрхий дутмаг, бага, мөчүү болох; *мөчиддөөд барьж болохгүй байна; мөчиддөөвөл милтрана шүү, лав барь!* 2. ш и л ж с э н хөнгөн хийсвэр болох.

МӨЧИДДҮҮЛЭХ мөчиддөхийн үйлдүүлэх хэв, мөчид болгох.

МӨЧИДХӨН баахан мөчид, арай мөчид.

МӨЧИЛ давжаа жижигхэн хүүхэд.

МӨЧИР 1. аливаа ургамлын салаа, сэлтэр; **салаа мөчир** х о р ш.; *хуурай мөчир түлнэ;* 2. аливаа юмны салаа, салбар; *хөдөө аж ахуйн салаа мөчир.*

МӨЧИРЛӨХ 1. ургамлын мөчир салааг салгах; *мод мөчирлөх;* 2. салбарлах.

МӨЧИРЛҮҮЛЭХ мөчирлөхийн үйлдүүлэх хэв.

МӨЧИРХӨГ мөч чац урттай.

МӨЧИРХӨХ мөчирхөг байдлаа гайхуулах, мөчирхөг байдлаараа давуурхах, мөч чац сайтай.

МӨЧИРХҮҮ мөчирхөг; *мөчирхүү хүүхэд байна.*

МӨЧИС мөчүү тачуу, ядуу дорой, баахан мөчид.

МӨЧИСДӨХ хэтэрхий мөчис болох, дутах.

МӨЧИХ I эрдмийг шалгах, сорих.

МӨЧИХ II модны салаа мөчрийг цавчин аридгах.

мөчлөг 1. зурхайн ёсонд арван хоёр жил; **мөчлөг орох** (жил орох); 2. эрдэм сурлагын шалгалт, сорилт; **мөчлөг өгөх** (шалгалт өгөх); мөчлөг авах (шалгалт авах).

мөчлөглөх 1. мөчлөг шалгалт авах; 2. мөчлөг тохиолдох.

мөчлөх мөч болгох, мөч мөчөөр хуваах, салгах; *энэ махыг мөчилж эвдээрэй.*

мөчөөгөө: мөчөөгөө өгтөхгүй барагтайд дийлэгдэхгүй; *мөчөөгөө өгтөхгүй, амаргүй хүн.*

мөчөөрхөх хүч дутахгүй гэж харилцан тэмцэх, эсэргүүцэх; *чи миний өмнөөс мөчөөрхөх хэрэггүй.*

мөчөөрхүүлэх мөчөөрхөхийн үйлдүүлэх хэв, мөчөөрхөхөд хүргүүлэх.

мөчүү зэхий зөвхөн, дөнгөж хүрэхүйц; *мөчүү хүрэв;* **мөчүү тачуу** хорш.,

мөчүүдүүлэх мөчүүдэхийн үйлдүүлэх хэв, мөчүү болгох.

мөчүүдэх хэтэрхий мөчүү болох.

мөчүүлэх 1. мөчихийн үйлдүүлэх хэв; 2. мөчигдөх.

мөшгөгдөх мөшгөхийн үйлдэгдэх хэв.

мөшгөлөг мөрдлөг.

мөшгөлт мөрдөлт.

мөшгөөр юмны зах ирмэгээр янзлан хийсэн хажаас ба түүний дотуур баахан зайтай хийсэн хошмог эмжээр; *мөшгөөртэй дээл; мөшгөөртэй бүрээс.*

мөшгөөрлөх мөшгөөр хийх.

мөшгөөрлүүлэх мөшгөөрлөхийн үйлдүүлэх хэв.

мөшгөх I мөрдөх, мөрөөр нь хөөх; *мөшгөн хянах; мөрий нь мөшгөх.*

мөшгөх II мөшгөөрлөх.

мөшгүүлэх 1. мөшгөхийн үйлдүүлэх хэв; 2. мөшгөгдөх.

мөшөөлт: мөшөөлт цэцэг ургамал дулаан оронд ургадаг, цэцэглэвч дүүрэн дэлгэрэхгүй, дөрвөн улиралд тасрахгүй цэцэглэдэг, өнгө цагаан хүрэн хоёр зүйл, өвөл нэн үнэртэй болдог нэгэн зүйл цэцэг.

мөшөөх мишээх, инээхийн хүндэтгэл.

мувга: мувга жимс ургамал дулаан орны уул завт өндөр сугдалсан модонд ургадаг, нанхиад арурын хэлбэртэй болоод хатуухан нэгэн зүйл жимс.

мугжгар тарган зузаалаг, пагдгар биетэй, хүзүү богино мэт байдалтай; *мугжгар загал; мугжгар бяруу.*

мугжийлгах мугжийхын үйлдүүлэх хэв, мугжгар болгох.

мугжийх мугжгар болох, мугжгар байдалтай харагдах; *мугжийсан сүрхий хүүхэд юм.*

мугзайх мухар нагжгар болох.

мугуйд 1. зүй ёсыг үл хайхрах, зөрүүд зантай; 2. тэнэг.

мугуйдагдах мугуйдахын үйлдэгдэх хэв.

мугуйдалт зоригоор бүрэмдэн мугуйдасан нь.

мугуйдах 1. хүчир авир гаргах, мундагдах; 2. гүжирдэх, гүтгэх.

мугуйддах хэтэрхий мугуйд болох.

мугуйдлагдах мугуйдлахын үйлдэгдэх хэв.

мугуйдлах 1. мугуйд зан гаргах; 2. мугуйдах.

мугуйдлуулах 1. мугуйдлахын үйлдүүлэх хэв; 2. мугуйдлагдах.

мугуйдуулах 1. мугуйдахын үйлдүүлэх хэв; 2. мугуйдагдах.

муж I 1. засаг захиргааны томоохон нэгж; *Москва мужийн намын хороо;* 2. бүс; *манай орны уулархаг муж.*

муж II этгээд, гажуу зан байдалтай.

мужаан модоч уран, модны дархан; *мужааны газар.*

мужигдах мужихын үйлдэгдэх хэв.

мужийх I 1. муриу сариу болох; 2. шилжсэн мугуйд зөрүү зан гаргах.

мужийх II дотор аягүй болох, идсэн зүйл шингэхгүй, дотор тэлэгдэх; *дотор мужийх.*

мужих 1. зөрүү муриу буюу этгээд зан байдал гаргах; 2. бөхийн мэх хажуу тийш дугтрах, булган гуядах, мурих.

мужлах муж болгон ангилж хуваах.

мужлуулах мужлахын үйлдүүлэх хэв.

МУЖУУ муриу, сариу, зөрүү; *мужуу зан.*

МУЖУУЛАХ 1. мужихын үйлдүүлэх хэв; 2. мужигдах.

МУЗГАЙ хазгай; **хазгай музгай** х о р ш.

МУЗГАР хазгар; **хазгар музгар** х о р ш..

МУЗЕЙ урлагийн дурсгал, техникийн зүйл, эрдэм шинжилгээний цуглуулга, түүхийн талаар сонирхолтой юмс зэргийг цугларуулах, хадгалах, нийтэд үзүүлэхээр үзэсгэлэн гаргах ажлыг эрхлэх байгууллага; *түүхийн музей; хувьсгалын музей; музейн үзмэр; музейн тайлбарлагч.*

МУЙХАР 1. тэнэг, зүтгээч; 2. зоригтой, эрэмгий.

МУЙХАРДАХ 1. муйхар зан байдал гаргах; 2. бачимдан тэвдэх.

МУЙХАРДУУ тэнэгдүү, зоримог байдалтай.

МУЙХАРДУУЛАХ муйхардахын үйлдүүлэх хэв.

МУЙХАРЛАГДАХ муйхарлахын үйлдэгдэх хэв.

МУЙХАРЛАХ тэнэг муйхраар аашлах.

МУЙХАРЛУУЛАХ 1. муйхарлахын үйлдүүлэх хэв; 2. муйхарлагдах.

МУЛГАР мөр өнцөггүй юмны мөр элж мухар болсон нь: **мулгар хулгар** х о р ш..

МУЛГАХ юмны учир чанарыг мэдэхгүй будлих.

МУЛГУУ ухаан муутай тэнэгдүү; *мулгуу амьтан.*

МУЛГУУВТАР арай мулгуу.

МУЛГУУДАХ мулгуу байдал гаргах.

МУЛГУУРАХ мулгуу болох.

МУЛГУУХАН баахан мулгуу.

МУЛЗЛАХ идэш уушны зэрэг зүйлийг шалзлах.

МУЛТ хүч нэмэгдүүлэх үг; *мулт татах; мулт цохих.*

МУЛТЛАГДАХ мултлахын үйлдэгдэх хэв.

МУЛТЛАХ 1. мултрахад хүргүүлэх; *моринын хоо хазаарыг мултлан тавив;* 2. булгалах; *шагаагаа мултлах.*

МУЛТЛУУЛАХ 1. мултлахын үйлдүүлэх хэв, 2. мултлагдах.

МУЛТРАМТГАЙ мултрахдаа хялбархан, амархан мултардаг.

МУЛТРАМХАЙ мултрах зантай, байн байн мултардаг.

МУЛТРАХ 1. уясан, угласан, шүргуулсан, ивсэн зэрэг юм огцрон гарах; *уяа мултрах; углуургаараа мултрах;* **уе мултрах** (а. мөч гишүүний уе булгарах; б. арван хоёр жилээс илүү ахмад настай болох); 2. ш и л ж с э н ангижрах, хагацах; *ялаас мултрах; боолчлолоос мултрах.*

МУЛТРУУЛАХ мултрахын үйлдүүлэх хэв, мултрахад хүргүүлэх.

МУЛТЧИХ байн байн буюу зэрэг зэргээр мултлах.

МУЛТЧУУЛАХ мултчихын үйлдүүлэх хэв.

МУНА 1. цохих дэлдэх тал нь бүдүүн булцгар, өөрөөсөө үргэлж эсхүл тусгай иштэй мод буюу төмөр зэвсэг; ☆ **мунан шил** (химийн шинжилгээний ажилд хэрэглэх урт хүзүүтэй шил сав); 2. тариа түгших түгшүүр.

МУНАГ 1. зөнөг; **зөнөг мунаг** х о р ш.; 2. буруу гажуу өтөлсөн нь.

МУНАГЛАХ 1. зөнөглөх; 2. буруугаар өтлөх.

МУНАГТАХ мунаг зөнөг байдал гаргах, зөнөгтөх.

МУНАДАХ мунаар цохих дэлдэх.

МУНАДУУЛАХ мунадахын үйлдүүлэх хэв.

МУНАЙД 1. мугуйд, тэнэгдүү; 2. архинд хэтэрхий орсон.

МУНАЙДЛАХ мунайд зан гаргах.

МУНАХ зөнөх, нас хөгширч маш доройтох; **зөнөх мунах** х о р ш..

МУНГАНИХ будлих, мухардах, гайхах, мунгинах.

МУНГИНАА мунгинасан нь; *мунгинаа нь хэтэрсэн хүн.*

МУНГИНАХ үйл явдалд дэмийр олохгүй будлих, самуурах, төөрөгдөх, мунганих; *өглөөнөөс авч мунгинаад одоо хүртэл хөдөлж чадахгүй байна.*

МУНГИНУУ хэтэрхий мунгинасан нь.

МУНГИНУУЛАХ мунгинахын үйлдүүлэх хэв, мунгинахад хүргүүлэх.

МУНДАА адуу малын сэрвээ дээрх, дэлийн мохолтын орчин дахь овгор газар; *морины мундаа.*

МУНДАГ сүрхий, бузгай, лут; *мундаг том шар; мундаг чанга дуугарах; мундаг сайхан.*

МУНДАГДАХ 1. хүч сүрээр буримдах; 2. хэтэрхий мундаг болох.

МУНДАГДУУЛАХ мундагдахын үйлдүүлэх хэв.

МУНДАГЛАХ 1. мундаг зан байдал гаргах; 2. хүч сүрээр дарамтлах.

МУНДАГЛУУЛАХ 1. мундаглахын үйлдүүлэх хэв; 2. мундагдуулах.

МУНДАЛГҮЙ мундахгүй.

МУНДАР шившиг, осол алдаа; *мундраа хутгах; мундраа тарих;* **мундар шившиг** х о р ш..

МУНДАРТАЙ мундар шившиг бүхий; *тэр чинь мундартай амьтан.*

МУНДАС бөгс орчинд хэд хэдэн хатиг нэгэн хэсэг газар бөөгнөрөн гарах өвчин.

МУНДАХ бишгүй, зөндөө, элбэг байх; **тэр зэргийн юм аль мундах вэ** (цөөнгүй).

МУНДАХГҮЙ бишгүй, зөндөө, өдий төдий, чамлахаар биш; *мундахгүй олон захидал ирэв; мундахгүй бужигнаан болжээ; мундахгүй их мөнгө өгөв.*

МУНДАШГҮЙ элбэг дэлбэг, их; *бие хайрлахгүй бол, хийх ажил мундашгүй дээ.*

МУНДИР ёслолын хувцас.

МУНИГ а м ь т а н цэнгэг усны өчүүхэн биет загас, хиймэл сувд хийхэд ч хэрэглэх нь бий.

МУНХАГ 1. тэнэг, мохдог; ухаан сэргэлэн биш; *ухаантантай маргалдвал эрдэм гарах, мунхагтай маргалдвал баас гарах х у у ч.;* **харанхуй мунхаг** х о р ш.; 2. х у у ч и р с а н аливаа тодорхойгүй юм; *мунхаг хэрэг; мунхаг цаг;* ☆ **мунхаг балрын хэм** (балар эртний цаг).

МУНХАГДАХ хэтэрхий мунхаг болох.

МУНХАГЛАХ 1. тэнэг мунхгаар аашлах; 2. санах бодох; *энэ хэргийг ингэвэл ямар вэ гээд би мунхаглаж байна.*

МУНХАГРАХ мунхаг болох.

МУНХАГТАХ мунхаг байдал гаргах.

МУНХАГШИХ мунхгийн шинжтэй болох.

МУНХРАЛ мунхрах нь; *насны мунхрал ирж байна.*

МУНХРАХ мунхуурах.

МУНХРУУЛАГЧ мунхруулдаг юм; *шашин бол ардыг мунхруулагч хар тамхи мөн.*

МУНХРУУЛАХ мунхрахын үйлдүүлэх хэв; *мунхруулах суртал.*

МУНХРУУЛГА мунхруулах үйлийн нэр; *шашны мунхруулгад автагдаж болохгүй.*

МУНХУУРАХ ухаан дортож муудах; *наснаад мунхуурч гүйцжээ; мунхууртлаа согтсон байв.*

МУНХУУРУУЛАХ мунхуурахын үйлдүүлэх хэв.

МУНЦ муна, нүдүүр; *модон мунц.*

МУНЦДАХ мунадах, нүдэх.

МУНЦДУУЛАХ мунцдахын үйлдүүлэх хэв.

МУРИЙ арай; **арай мурий** х о р ш..

МУРИУ 1. гажуу, сариу; **муриу гажуу, муриу сариу** х о р ш.; 2. ш и л ж с э н шудрага биш, тэрс; 3. ш и л ж с э н зүйгүй; эелдэг биш.

МУРИУЛАХ мурихын үйлдүүлэх хэв.

МУРИХ 1. бөхийн мэх, эсэргүүцлийн этгээдийг барин авч өмнүүр нь зөрөн эргэж мурисхийн унагах; 2. ш и л ж с э н бусадтай тэмцэхдээ хүч чадлаар биш, арга хашраар дийлэх.

МУРУЙ 1. шулуун цэх биш, хазгай тахир; *муруй шугам; муруй зурах; муруй боловч зам дөт* з ү й р; 2. ш и л ж с э н замаас гажуу, тойруу; *замаас муруй.*

МУРУЙЛГАХ муруйхын үйлдүүлэх хэв.

МУРУЙХ 1. хазгай тахир болох; *чиг явж байгаад муруйжээ;* ☆ *ам муруйх* (зөрөх, маргах); 2. замаас гажиж явах; *зам муруйхад хүрэв.*

МУРЧГАНАХ мурчгар юмны мурчга мурчга хөдлөх.

МУРЧГАР 1. муруй мушгиу, арчгар үрчгэр; 2. ш и л ж с э н ууртай, мушгиач.

МУРЧИЙХ 1. мурчгар болох, арчийх, мүрчийх; 2. ш и л ж с э н уур хилэнтэй, мушгиач болох.

МУРЧИЛЗАХ мурчгар юмны мурчис мурчис хийх.

МУТАР гарын хүндэтгэл.

МУТАРЛАХ 1. гараар барихын хүндэтгэл; 2. гарын үсэг зурахын хүндэтгэл.

МУТАРЛУУЛАХ мутарлахын үйлдүүлэх хэв.

МУУ сайнтай эсэргэлдсэн утга; 1. **сайн биш, хар хор**, харш хөнөөл бүхий; *муу зан гаргах; муу эд; муу тал; муу буруу; муу сэтгэл; муугийн муу; муугаас зайл!* **муу заяа** (сайн биш хувь зохиол); **муу ёр** (сайн биш шинж тэмдэг): **муу сурамгай** (мууд дадлагатай болсон нь); **муугий нь дуудах** (бусдын муу буруу явдлыг илрүүлэн гаргах); **муугий нь үзэх** (тарчилган зовоох); **муу хүн** (а. хор хөнөөлтэй, муу санаатай, нөхрийн ханшгүй; б. хулгайч, луйварчин); **хүн муутай** (хүний ханилгаа, чанар муутай, нөхрийн ханш мөс муутай); **бие муутай** (а. бие өвчтэй буюу дорой; б. бие жирэмсэн); **муу өдөр** (а. ажил үйл хийхэд бүтэмж муутай; б. бороо, цас, салхи, шуургатай өдөр; в. х у у ч и р с а н ажил үйл хийж болохгүй гэсэн цээрт өдөр); **муу цаг** (а. х у у ч и р с а н цөвийн цаг: б. хэвийн биш ховор гачиг цаг); **муу муудаа ноён** (илүү дээр биш атлаа дээрэлхэх байдал гаргах); **муу олгой** (мухар олгой); **муу сархинаг** (хивдэг амьтны гүзээний хажууд байх салбантай жижиг гүзээ); **муу сайн** (а. сайн муу нийлсэн юм; б. голж үл тоомсорлосон санааг илтгэхэд хэрэглэнэ; *муу сайн юмд адуу маллаж чадахгүй байна);* **муу мянган** (өвөр монголын нэгэн аймаг); **муу л бол хойт захын хар овоохой** (дорой буурайд гэм буруу бүхнийг чихэх); *сайн санааны үзүүрт сүүтэй, муу санааны үзүүрт зүүтэй з ү й р; муу хүний үгэнд бүү ор х у у ч, муу хүн сонжооч, мухар үхэр сэжээч з ү й р;* 2. **хөөрхийлөлтэй**, ядуу, дорой, энхрийлэл, өхөөрдөл; *муу өвгөн минь; муу морь минь; муу нөхөр нь; муу охин минь; миний муу найз.*

МУУВТАР арай муу.

МУУВИН: муувин цаас цагаан будааны хэвгээр хийсэн цаас.

МУУДАХ 1. хэтэрхий муугийн үчир тохиромжгүй болох; *ийм гоё байшинд гэрэл нь мууджээ; энэ будгийн өнгө нь муудаад байна;* 2. муу болох; *би түүнд муудав; бие муудаад байна.*

МУУДУУЛАХ муудахын үйлдүүлэх хэв.

МУУЖРАХ ухаан мэдрэл алдаж үхэтхэн унах; *муужран унав.*

МУУЖРУУЛАХ 1. муужрахын үйлдүүлэх хэв; 2. нядлах.

МУУЛАГДАХ муулахын үйлдэгдэх хэв.

МУУЛАМТГАЙ муулах дуртай.

МУУЛАМХАЙ муулах зантай, бусдын мууг дуудах дуртай.

МУУЛАХ бусдын мууг ховлон хэлэх; *хүн муулахдаа дуртай.*

МУУЛУУЛАХ 1. муулахын үйлдүүлэх хэв; 2. муулагдах.

МУУР а м ь т а н мийн язгуурын сүүн тэжээлт, гэрийн тэжээмэл мий гэдэг амьтны эр.

МУУРАХ муужрах, ухаан алдах.

МУУСАЙН муу сайн.

МУУТАХ 1. улам муу болох, доройтох; *хадуурын ир муутав;* **бие муутах** (өвдөх); 2. элэгдэж хуучрах; *гутал муутаж явна;* 3. хэрэлдэх, **эвдрэх; муутах хэрэлдэх** х о р ш.

МУУТГАХ муутахын үйлдүүлэх хэв, муу болгох.

МУУТГУУЛАХ муутгахын үйлдүүлэх хэв.

МУУТУУ олсоор хийсэн цаас; *муутуу цаас.*

МУУХАЙ 1. үзэмжгүй, гуа биш, балмар; *муухай болох; муухай царайтай; муухай юм;* **муу муухайд нь хүрэх** (хараах доромжлох): *муухай үнэртэй байна; таны орон гэр их муухай байна;* 2. хэрцгий, ширүүн, элдэг биш; *муухай харах; муухай аашлах;* 3. ш и л ж с э н шудрага биш муу санаатай; *муухай ажил хийж байна; муухай хүн;* 4. харамсмаар, аягүй; *тоогүй муухай; муухай явдал боллоо! өвдөөд их муухай болжээ;* 5. энхрийлсэн, өхөөрдсөнд хэрэглэнэ; *миний муухай хүү аавдаа ир! муухай жаал байна.*

МУУХАЙВТАР арай муухай.

МУУХАЙДАХ хэтэрхий муухай болох.

МУУХАЙРАХ муухай болох.

МУУХАЙТАХ улам муухай болох.

МУУХАЙТГАХ муухай болгох.

МУУХАН арай муу, баахан муу.

МУУХАНДУУ арай муухан, баахан муухан.

МУУЧЛАГДАХ муучлахын үйлдэгдэх хэв.

МУУЧЛАХ 1. доромжлон зовоох; мууд үзэх; 2. муулах; *та нар намайг битгий муулаад байгаарай!*

МУУЧЛУУЛАХ 1. муучлахын үйлдүүлэх хэв; 2. муучлагдах.

МУУШААГДАХ муушаахын үйлдэгдэх хэв.

МУУШААЛ муутган хэлэх үг.

МУУШААЛГАХ 1. муушаахын үйлдүүлэх хэв; 2. муушаагдах.

МУУШААХ сайшаахтай эсэргүүцэлдсэн утга; мууд үзэх, муудтооцох, үл ойшоох, үл тоомсорлох, буруушаах; *архи уугаад согтууразхыг ихэд муушаана.*

МУХАР 1. аливаа юмны онцлог, ир, үзүүрийг мохоон мухлайдсан мөлүү; *мухар хутга;* **мухар толгой** (а. соруулгүй гаанс; б. гэзэгтүй толгой); **мухар ханцуйтай дээл** (нудрагагүй дээл); **мухар олгой** (олгойн хажууд унжсан бяцхан зүйл; *мухар олгой үрэвсэх; мухар олгойтох);* ☆ **мухар сүсэг** (хоцрогдсон бүдүүлэг хүмүүсийн элдэв юмыг бурхан тэнгэр бүтээнэ гэж сохроор итгэх итгэл бишрэл; *шашны мухар сүсэг);* **мухар чийх** (хавдаж бээр шүүс тэрэвч, нэвчиж цоорохгүй битүүгээр буглах яр); 2. эвэргүй; *мухар ямаа; мухар үнээ; муу хүнийг модоор, мухар үхрийг ноготоор* з ү й р; 3. ш и л ж с э н хэрэглэх багаж зэвсэггүй; *гар мухар болох;* 4. юмны битүү булан; *нүхний мухар; хүүдийний мухар* (ёроол); **мухар гудамж** (нэвт гарахгүй гудамж); **гэрийн мухар сахих** (гэрээс үл гарах); 5. алс буйд, хол; *газрын мухарт суух.*

МУХАРДАЛ мухардах үйлийн нэр; *мухардалд орох.*

МУХАРДАХ 1. юмны мухар, битүү, буланд тулгарах; *доголд мухардах;* 2. ш и л ж с э н ажил үйлийг бүтээж чадахгүй арга барагдах; *арга мухардах;* 3. ш и л ж с э н үг олж хэлж чадахгүй болох; *үгэнд мухардах.*

МУХАРДУУЛАХ мухардахын үйлдүүлэх хэв, мухардахад хүргүүлэх.

МУХАРЛАХ 1. мухар болгох, үзүүргүй болгох; 2. хэрэглэх хэрэгсэл юмгүй болгох; *морий нь унаад мухарлаж орхив; ташуурыг нь аваад гарыг нь мухарлажээ;* 3. алдсан гээсэн юмыг эрэн сурвалжилж цөхөх; *эрж мухарлах; хэдэн адуу эрээд ам хөндий мухарлаад ирэв;* 4. иш улыг лавлан олох; *мухарлаж мэдэх.*

МУХАРЛУУЛАХ 1. мухарлахын үйлдүүлэх хэв; мухарлахад хүргүүлэх; 2. мухарлагдах.

МУХИР тахир; **тахир мухир** х о р ш.; *мухир гудамж.*

МУХЛАГ 1. дээгүүрээ бүрхүүл бүхий үүдтэй тэрэг; *мухлаг тэрэг;* 2. бүхээг; *барааны мухлаг; идэш уушны мухлаг.*

МУХЛАЙДАХ 1. тумлайдах, сэжүүр өнцгийг нугасхийн доогуур нь оруулж битүү болгох; *хөгшин эхийнхээ хөлийг мухлайдан хучив;* 2. далдуур лавлах; *мухлайдаж асуух.*

МУХЛАЙДУУЛАХ 1. мухлайдахын үйлдүүлэх хэв; 2. мухлайдагдах.

МУХЛИ я р и а зарц, боол.

МУХРИУЛАХ мухрихын үйлдүүлэх хэв, тонгоргох, унагаах, хөмрөх, өнхрүүлэх.

МУХРИХ тонгоргох, унагах, хөмрөх, өнхрөх.

МУШГАР илт мэдэгдэм зөрүүд байдалтай буюу дуугүй, ихэрхэн цэмцгэр байх; *мушгар хүн.*

МУШГИА 1. мушгиж бөөгнүүлсэн юм; *нэг мушгиа унгас; мушгиа утас;* 2. мушгиж хийсэн юм; *ачаатай түлээг мушгиагаар татав.*

МУШГИАЧ 1. мушгих ажилтай; 2. мушгих зантай; 3. ш и л ж с э н зүй ёсыг бодохгүй санаснаа зөв болгохыг хичээдэг зүтгээч.

МУШГИГДАХ мушгихын үйлдэгдэх хэв.

МУШГИЛАХ байн байн мушгих; **гэдэс мушгилах** (гэдэс мушгисан мэт сүрхий өвдөх).

МУШГИЛУУЛАХ мушгилахын үйлдүүлэх хэв.

МУШГИМАЛ мушгисан юм; *мушгимал нооc.*

МУШГИРАХ 1. мушгиа эрч орох; 2. шулуун шудрага биш болох.

МУШГИУ 1. гажуу, сариу, шулуун биш; *могойн зулзага нарийн боловч мушгиу хэвтэх зантай, мигуйн зулзага бага боловч мяраах зангаа болихгүй* з ү й р; 2. ш и л ж с э н шудрага биш.

МУШГИУЛАХ мушгихын үйлдүүлэх хэв, мушгихад хүргүүлэх.

МУШГИХ 1. юмны хоёр этгээдээс барьж эрчлэн эргүүлэх; *цамцаа угаагаад мушгив; дээс мушгин эрчийг чангалав;* 2. ш и л ж с э н хилсдүүлэх, хүчээр тулган хүлээлгэх, мугуйдах; *бурууган мушгих; мушгин гужирдэх; буримдан мушгих;* **сүүл мушгих** (сүүлд орох, сүүлийг барих, адагт орох, бөгсөнд орох); **гэдэс мушгих** (гэдэс базлан өвдөх).

МУШИЙЛГАХ мушийхын үйлдүүлэх хэв, мушийхад хүргүүлэх.

МУШИЙХ мушгар зан байдал гаргах.

МУШИЛЗАХ инээмсэглэх байдал илрэх; *дуртай дургүй мушилзаж харагдав.*

МУШИЛЗУУЛАХ мушилзахын үйлдүүлэх хэв.

МҮГЛЭН х у у ч и р с а н шорон, гяндан.

МҮҮ тариалангийн газрын хэмжээ, нэг мүү газар нь өргөн гурван хос, урт нь арван найман хос алд (нэг га газрыг арван зургаа хуваасны нэгтэй тэнцэнэ); **мүү царцаахай** а м ь т а н (тарианы угийг иддэг нэг зүйл хорхой).

МЭГ з у р х а й сарны зурхайн ёсны хорин найман одны нэгийн нэр.

МЭГДРЭХ тэвдэж сандраад яах учраа үл олох; *би ч мэгдэрч гүйцлээ, юу болохыг ч бүү мэд л байна.*

МЭГДҮҮ тэвдүү, сандруу, яруу, давчуу.

МЭГДҮҮЛЭХ мэгдэхийн үйлдүүлэх хэв, яруулах, тэвдүүлэх.

МЭГДҮҮХЭН арай мэгдүү, арай тэвдүү, арай сандруу.

МЭГДЭЛ мэгдэх үйлийн нэр, яарал, сандрал, тэвдэл.

МЭГДЭХ тэвдэх, яарах, адгах, сандрах.

МЭГДЭЭХ сандраах, тэвдээх, яруулах, бачимдуулах.

МЭГЖ дөрвөн настайгаас дээших эм гахай.

МЭДЛЭГ мэдэл, мэдэц; *оюун мэдлэг; ухаан мэдлэг; сурлага мэдлэг.*

МЭДРҮҮЛЭХ мэдрэхийн үйлдүүлэх хэв, сэхээрүүлэх, ухааруулах, таниулах.

МЭДРЭЛ 1. бие махбодын үйл ажиллагаа, хүний зан байдлыг магадлан тогтоох эрхтнүүдийн системийн нэгдэхүүн; *мэдрэлийн систем;* **мэдрэл орох** (а. амьтан юмны мэдээ орж эхлэх; б. ухаан алдаад сэхэх): **мэдрэл муудах** (мэдрэлийн эрхтэнд гэм согог сууж өвчлөх); **мэдрэлийн судал** (бие махбодын үйл ажиллагааг эрхлэх тархи, нугаснаас салаалсан системийг бий болгох маш нарийн ширхгүүд; *харааны мэдрэлийн судал);* **таван мэдрэл** (үзэхүй, сонсохуй, үнэрлэхүй, амтлахуй, хүрэлцэхүй); **мэдрэлийн эрхтэн** (нүд, чих, хамар, хэл, бие); 2. мэдэц, боловсрол; *мэдрэл ихтэй; мэдрэл сайтай.*

МЭДРЭХ 1. ухаж туулах, ухамсарлах; *мэдэрч сэнхрэх;* 2. мэдрэл төрөх, мэдрэлээр мэдэх, гадаад орчны байдлыг мэдрэлдээ хүлээн авах; *халуун хүйтнийг мэдрэх.*

МЭДРЭХҮЙ гадаад орчныг мэдрэлдээ хүлээн авахуй чанар; **мэдрэх эрхтэн** (нүд, чих, хамар, ам, бие).

МЭДҮҮЛЭГ 1. өчиг, байцаахад өгсөн хариу; *хэрэгтний мэдүүлэг;* 2. мөнгө юм тушаах баримт бичиг, хуудас; *мэдүүлгийн хуудас; мэдүүлэг бичих;* 3. өрөгдөл бичиг.

МЭДҮҮЛЭЛ мэдүүлэг.

МЭДҮҮЛЭХ 1. мэдэхийн үйлдүүлэх хэв, мэдэхэд хүргүүлэх; 2. мэдэгдэх; 3. мэдүүлэг өгөх; **толгой мэдүүлэх** (бусдын эрхшээлд бүрэн орох).

МЭДЭГДЭЛ амаар буюу бичгээр өгсөн албан ёсны санамж; *мэдэгдэл хийх; Монголын цахилгаан мэдээний агентлагийн мэдэгдэл.*

МЭДЭГДЭМ хялбархан мэдэгдэж болох зүйл.

МЭДЭГДЭХ 1. мэдэхийн үйлдэгдэх хэв; 2. ухагдах, сэрэгдэх; 3. мэдээлэх.

МЭДЭГДЭХҮҮН мэдэгдэх юм, мэдэгдүүлэх юм; *улс төрийн мэдэгдэхүүн; арцун цэврийн анхны мэдэгдэхүүн.*

МЭДЭЛ 1. мэдлэг; **онол мэдэл** х о р ш.; 2. эрх тушаал, эрх; **эрх мэдэл** х о р ш.; *бидний мэдлийн юм; өөрийн мэдэлгүй; мэдэл ихтэй* (эрх ихтэй).

МЭДЭЛТЭЙ 1. мэдлэг ихтэй, мэдэл сайтай; 2. голлож мэддэг; *мэдэлтэй хүн нь тэр.*

МЭДЭМХИЙ мэдсэн мэт онгироо зантай.

МЭДЭМХИЙЛЭХ мэдэмхий байдал гаргах.

МЭДЭМХИЙРХҮҮЛЭХ *мэдэмхийрхэхийн* үйлдүүлэх хэв.

МЭДЭМХИЙРХЭХ мэдэмхийрэх.

МЭДЭМХИЙРЭХ мэдэмхий зан гаргах.

МЭДЭРХЭГ хөөргөн, онгироо, мэдэхгүй мөртөө мэддэг юм шиг царай гаргадаг.

МЭДЭРХЭХ мэдэмхийрэх, бага мэдэвч их мэдэх байдал гаргах.

МЭДЭРХЭЭЧ мэдэмхий, онгироо зантай.

МЭДЭХ 1. ухвар мэдээтэй байх; *тэд хааш явахыг би мэднэ; тэр тухай та л мэдэх ёстой; „мэднэ, мэднэ" гэж хэлээд мордон явлаа; хамаатан садныаа гэж мэддэг байв;* 2. ухаж ухамсарлан авах, ойлгох; *хэлсэн үгийн учрыг мэдэв; харахтайгаа зэрэг мэдэв;* 3. ямар нэг зүйлийн мэдэцтэй болох; *бичиг мэдэх; хятад хэл мэддэг; мэдье гэвэл сурах хэрэгтэй, суръя гэвэл сонсох хэрэгтэй* х у у ч; *жор мэдэхгүй эмчээс зовлон үзсэн чавганц дээр* з ү й р; 4. танил байх; *би түүнийг багаас нь мэднэ; таних мэдэх хүн;* **толгой мэдэх** (а. биеэ даах; б. өөрийн бодолтой байх); **цаг мэднэ** (цагийн харгаагаас болно); **ажил мэднэ** (а. ажил хийж чадна; б. ажлын байдлаас болно); **аз мэдэг** (аз заяанд дулдуйдах); **заяа мэдэх** (аз хувьд дулдуйдах): **хэрэг мэдэх** (хэргийн учир шалтгааныг нарийн ялгаж мэдэх); **үнэр мэдэх** (а. үнэр сэрэгдэх; б. ажиг сэдэв төсөөлөх); **учир мэдэх** (учир ойлгох); **хэл мэдэх** (а. харь хэл сурсан; *Англи хэл мэдэх хүн байгаа юм;* б. учир ойлгосон; *тэр ч хүний хэл мэдэх хүн байгаа юм);* **бүү мэд** (мэдэхгүй); **мэдтүгэй гэсэн бичиг** (а. нот; б. тулган шаардах бичиг).

МЭДЭЦ мэдлэг, боловсрол, ухвар; *мэдэц сайтай; мэдэц дорой; улс төрийн мэдцийн хэмжээг дээшлүүлэх.*

МЭДЭЧ мэдэх төсөөлөх нь бусдаас илүү.

МЭДЭЭ I сонсгон мэдэгдэх зүйл, сонсгох үг; *мэдээ авах; мэдээ оруулах; лавтай мэдээ; мэдээ гаргах; хэвлэлийн мэдээ; Шинжлэх Ухааны Академийн мэдээ сэтгүүл.*

МЭДЭЭ II мэдрэл, ухаан; *мэдээ орох; мэдээ орсон хүүхэд; өөрийн мэдээтэй байх; мэдээ алдах.*

МЭДЭЭ III мэдэл, эрх; *мэдээтэй хүн; мэдээ ихтэй.*

МЭДЭЭЖ мэдэж байгаа нь; *мэдээж хэрэг.*

МЭДЭЭЛҮҮЛЭХ 1. мэдээлэхийн үйлдүүлэх хэв; 2. мэдээлэгдэх.

МЭДЭЭЛЭГДЭХ мэдээлэхийн үйлдэгдэх хэв.

МЭДЭЭЛЭГЧ мэдээ өгөх үүрэг бүхий хүн.

МЭДЭЭЛЭЛ мэдээлэх юм; *Мэдээлэл радиогийн хэрэг эрхлэх газар.*

МЭДЭЭЛЭХ мэдээ оруулах, мэдэгдэх, сонсгох; *мэдээлэх товчоо.*

МЭДЭЭТЭЙ 1. мэдээ бүхий; *мэдээтэй байх;* 2. эрх мэдэлтэй; 3. ухаантай.

МЭДЭЭТЭЙХЭН болгоомжтойхон, анхаарал тайхан, сэрэмжтэйхэн.

МЭДЭЭЧ эрх мэдэлтэй хүн; *сангийн мэдээч; дацангийн мэдээч.*

МЭЛ гөлийх, гайхах, алмайрах нь; *цэл хөхөрч, мэл гайхах.*

МЭЛГЭН эзгүй, хоосон, юу ч үгүй; *мэлгэн гал газар.*

МЭЛГЭР 1. цэлгэр; цэлгэр *хөндий; цэлгэр* байшин; 2. нэлгэр; *мэлгэр ус.*

МЭЛГЭЭН хоосон, мэлгэн; **мэлгээн хоосон** х о р ш . .

МЭЛЗИЙХ мэлзэн болох, халзан болох.

МЭЛЗҮҮЛЭХ 1. мэлзэхийн үйлдүүлэх хэв; 2. мэлзэгдэх.

МЭЛЗЭМТГИЙ мэлзэхдээ дуртай.

МЭЛЗЭМХИЙ мэлздэг заншилтай.

МЭЛЗЭН магнай маш өргөн, халзан; *мэлзэн духтай;* халзан **мэлзэн** х о р ш . .

МЭЛЗЭХ хэлсэн хийсэн үг явдлаа хэлээгүй хийгээгүй гэж ор тас зүтгэх, буцах, няцах; *үзээгүй гэж мэлзээгүй байна; мэлзэж мэлзээд давсангүй.*

МЭЛЗЭЭ мэлзэх үйлийн нэр; *мэлзээ хийх; мэлзээ тавих.* -ᠮᠡᠯᠵᠡᠶ

МЭЛЗЭЭЛЭХ юмны илүү дорыг булаалдан тэмцэх, тэнсэлцэх; -ᠮᠡᠯᠵᠡᠯᠡᠬᠦ

МЭЛЗЭЭН мэлзээ. -ᠮᠡᠯᠵᠡᠶᠢᠨ

МЭЛЗЭЭЦЭХ мэлзээлэх; *бид хоёр мэлзээцэх болсон.* -ᠮᠡᠯᠵᠡᠯᠴᠦᠬᠦ

МЭЛЗЭЭЧ сүрхий мэлздэг. -ᠮᠡᠯᠵᠡᠶᠴᠢ

МЭЛИГНЭХ мэлгэр юмны мэлэг мэлэг хийх. -ᠮᠡᠯᠢᠭᠨᠡᠬᠦ

МЭЛИЙЛГЭХ мэлийхийн үйлдүүлэх хэв. -ᠮᠡᠯᠢᠶᠢᠯᠭᠡᠬᠦ

МЭЛИЙХ 1. цэлийх; *мэлийсэн тал газар; мэлийсэн сайхан тасалгаа;* 2. нэлийх, мэлрэх; *мэлийсэн их ус.* -ᠮᠡᠯᠢᠶᠡᠬᠦ

МЭЛМИЙ нүдний хүндэтгэл; -ᠮᠡᠯᠮᠢᠶ

МЭЛМЭЛЗҮҮЛЭХ мэлмэлзэхийн үйлдүүлэх хэв. -ᠮᠡᠯᠮᠡᠯᠵᠦᠦᠯᠡᠬᠦ

МЭЛМЭЛЗЭХ мэлтэлзэх, шингэн юм сав дотроо бялхаж байх; ☆ **мэлмэлзэн уйлах** (нүдэнд нулимс дүүрэх). -ᠮᠡᠯᠮᠡᠯᠵᠡᠬᠦ

МЭЛРҮҮЛЭХ мэлрэхийн үйлдүүлэх хэв. -ᠮᠡᠯᠷᠦᠦᠯᠡᠬᠦ

МЭЛРЭГ у р г а м а л анхилам үнэртэй, цагаан цэцэгтэй, бутархаг ургамал. -ᠮᠡᠯᠷᠡᠭ

МЭЛРЭХ 1. элрэн гайхах; 2. гөлрөх. -ᠮᠡᠯᠷᠡᠬᠦ

МЭЛТИЙЛГЭХ мэлтийхийн үйлдүүлэх хэв, мэлтийхэд хүргүүлэх. -ᠮᠡᠯᠲᠢᠶᠢᠯᠭᠡᠬᠦ

МЭЛТИЙХ шингэн юмны маш дүүрэн байх; *мэлтийтэл дүүргэсэн хувинтай айраг сөгнөжээ.* -ᠮᠡᠯᠲᠡᠬᠦ

МЭЛТЭГНҮҮЛЭХ мэлтгэнэхийн үйлдүүлэх хэв; *хувинтай сүү мэлтэгнүүлэх.* -ᠮᠡᠯᠲᠡᠭᠨᠡᠯᠦᠦᠯᠡᠬᠦ

МЭЛТЭГНЭХ шингэн зүйлийн маш дүүрэн бялхалзаж байх; *мэлтэгнэтэл дүүргэх;* **мэлтэгнэн уйлах** (нулимс унагаан уйлах). -ᠮᠡᠯᠲᠡᠭᠨᠡᠬᠦ

МЭЛТЭЛЗҮҮЛЭХ мэлтэлзэхийн үйлдүүлэх хэв; *мэлтэлзүүлэн уйлаад яах билээ.* -ᠮᠡᠯᠲᠡᠯᠵᠦᠦᠯᠡᠬᠦ

МЭЛТЭЛЗЭХ шингэн юм саванд бялхан дүүрч бага зэрэг долгилох; *алтан амтай хундагад нь, амсар дүүрэн мэлтэлзүүлж...* (ерөөл); *алст тэнгэсийн ус мэлтэлзэн цэнхэртэнэ.* -ᠮᠡᠯᠲᠡᠯᠵᠡᠬᠦ

МЭЛХИЙ а м ь т а н хойт хоёр хөл нь дэвхрэн хөдлөхөд зохицсон урт бөгөөд сүүлгүй, газар усны хоёр нутагт амьтан; *ногоон мэлхий; намгийн мэлхий; мэлхийн шээс* [illegible] *нэмэр з ү й р; мэлхий харайвч м ө н дороо з ү й р;* **яст мэлхий** а м ь т а н (ясархаг хуягтай, богино хөлтэй, удаан хөдөлдөг, газар усныаа явагч амьтан): **мэлхий хаалга** (хашаа, хэрэм мөн том хаалганд хийсэн жижиг хаалга); **мэлхийн зам** (дэлхийн халуун бүсийн умард хэсгийн зааг уртраг шугам); ☆ **мэлхий ааруул** (аарцаар хийх базмал идээ); **алаг мэлхий** (шагаагаар өрж наадах тоглоом). -ᠮᠡᠯᠬᠢᠶ

МЭЛЦИЙМ огт өөр юмгүй цулгуй; *мэлциймтал хөндий.* -ᠮᠡᠯᠴᠢᠶᠮᠡ ᠭ

МЭЛЦЭГ саармаг. -ᠮᠡᠯᠴᠡᠭ

МЭЛЧИГ харвахад зорьсондоо хүрэхгүй зуур унасан нь. -ᠮᠡᠯᠴᠢᠭ

МЭЛЭЛЗҮҮЛЭХ мэлэлзэхийн үйлдүүлэх хэв. -ᠮᠡᠯᠡᠯᠵᠦᠦᠯᠡᠬᠦ

МЭЛЭЛЗЭХ мэлгэр юмны мэлс мэлс хөдлөх. -ᠮᠡᠯᠡᠯᠵᠡᠬᠦ

МЭЛЭЭД нилээд. -ᠮᠡᠯᠡᠶᠳ

МЭЛЭЭН я р и а нилээд; *мэлээн олон хүн харагдав.* -ᠮᠡᠯᠡᠶᠢᠨ

МЭНГЭ арьсан дээр урган тогтсон төрөлхийн толбо; **мэнгэ нь голлох** (хамаг хэрэг бүтэц муутай байх). -ᠮᠡᠩᠭᠡ

МЭНГЭР уушигны цагаан гуурснуудын салст бүрхэвч үрэвсэж өвчлөх өвчин; *мэнгэртэй болох;* **архаг мэнгэр** (бүгтрэн ханиах өвчин). -ᠮᠡᠩᠭᠡᠷ

МЭНГЭРЛЭХ мэнгэр тогтох. -ᠮᠡᠩᠭᠡᠷᠯᠡᠬᠦ

МЭНГЭРТЭХ мэнгэр өвчинтэй болох. -ᠮᠡᠩᠭᠡᠷᠲᠡᠬᠦ

МЭНГЭРШИХ мэнгэр тогтох шинжтэй болох. -ᠮᠡᠩᠭᠡᠷᠰᠢᠬᠦ

МЭНД 1. эсэн, энх тунх; *мэнд амар байх;* **амь мэнд** (үхсэнгүй, амьд); **мэнд өнгөрөх, мэнд гарах** (юманд өртөгдөхгүй өнгөрөх); **эрүүл мэнд** (амьд бие махбодын зөв ердийн үйл ажиллагаа); **эрүүл мэндийн бичиг** (биеийн байдлыг тодорхойлсон баримт); **эрүүл мэндийн байдал** (өвчтэй хүний биеийн байдал); **эрүүл мэнд, мэнд амар** х о р ш.; 2. хүн рүү танил дотныг илэрхийлэн хандахад хэлэх үг: **мэнд байна уу?** (сайн байна уу?); *мэнд сайн байцгааж байна уу? эрүүл мэндийн төлөө!* **мэнд мэдэх** (мэнд сайныг лавлан асуух); **мэнд хүргэх** (хүнээр дамжуулан мэнд сайныг асуух). -ᠮᠡᠨᠳ

МЭНДЛҮҮЛЭХ мэндлэхийн үйлдүүлэх хэв. -ᠮᠡᠨᠳᠯᠦᠦᠯᠡᠬᠦ

МЭНДЛЭХ I мэндийг асуух, мэндчилэх. -ᠮᠡᠨᠳᠯᠡᠬᠦ

МЭНДЛЭХ II төрөхийн хүндэтгэл; *Сүхбаатарын мэндэлсний ойг тэмдэглэх.*

МЭНДНИХ мунгинах, сандран тэвдэх.

МЭНДҮҮРЭХ сэтгэл зовниж дотор амаргүй болох.

МЭНДЧИЛГЭЭ мэндчилэх үйлийн нэр.

МЭНДЧИЛЭХ мэндлэх, харилцан амар мэндээ мэдэх.

МЭНДЭЛ яарал сандрал, түргэн түүхий; **мэндэл яарал** х о р ш..

МЭНДЭН тэвдэн, сандран, яаран; *мэндэн сандан гүйв;* **мэндэн сандан** х о р ш..

МЭНДЭХ мэгдэх, бачимдан тэвдэх; *ярч мэндэх хэрэггүй.*

МЭНЭГ 1. мөч гишүүн мэдрэлгүй болох өвчин; *мэнэг дайрах;* 2. ш и л ж с э н огт ухваргүй тэнэг.

МЭНЭГДЭХ хэтэрхий мэнэгийн учир тохиромжгүй болох.

МЭНЭГТЭХ 1. мэнэг өвчин тусах; 2. ш и л ж с э н дүйрэх; санаа төөрөгдөж учир зүйг олохгүй болох.

МЭНЭГШИХ мэнэгийн шинжтэй болох.

МЭНЭНЦЭР 1. мэнэг өвчтэй; 2. тэнэг; *мэнэнцэр хүн.*

МЭНЭРҮҮЛЭХ мэнэрхийн үйлдүүлэх хэв, дүйрүүлэх.

МЭНЭРЭХ 1. бадайрах, чинэрэх; *бие мэнэрэх;* 2 дүйрэх, дүйрэнгэ болох; *толгой дүйрч мэнэрэх;* 3. огт ухваргүй элий балай болох, элмэрэх; *аль ч учрыг олохгүй мэнэрч хоцорчээ.*

МЭР I: **мэр сэр** хааяа, энд тэнд, бага сага; *тийм үг мэр сэр сонсдоно; бичигтэй чулуу мэр сэр байдаг ажээ.*

МЭР II дотор өвчний өвдөх байдлыг илэрхийлэх үг; *мэр гэж өвдөх; мэр мэр хийх.*

МЭРГҮҮ тэнэг, ухваргүй; *үнэхээр ч мэргүү хүн юм даа.*

МЭРГЭД олон мэргэн, сэцэд.

МЭРГЭДЭХ ан хийхдээ зортой явах, ан элбэг тохиолдох.

МЭРГЭМШИХ мэдлэгтэй болох, мэдлэг эзэмших, дадлагатай болох.

МЭРГЭН 1. мэдлэг, туршлагаар үндэслэсэн их ухаан билэгтэй, сэцэн сэргэлэн; **сэцэн мэргэн** х о р ш.; *ачит мэргэн багш Ленинд ард түмэн бид биширнэ; намын мэргэн жолоодлогоор;* **мэргэн үг**(онож хэлсэн үг); 2. алдалгүй онодог; *мэргэн харваач; мэргэн бууч;* 3. сур харвахад түргүлсэн хүнд олгох цол; *улсын мэргэн; мэргэн тэр;* 4. х у у ч и р с а н төлөг үзэж тааварлагч; *мэргэн боловч алддаг, мэлхий боловч шаварддаг* з ү й р .

МЭРИЙЛГЭХ мэрийхийн үйлдүүлэх хэв.

МЭРИЙЛТ чармайлт, идэвхлэлт.

МЭРИЙМЖ мэрийлт, зүтгэл; *мэриймжтэй; мэриймжгүй.*

МЭРИЙХ чармайн зүтгэх, улайх, хичээх; *хожих гэж мэрийж байв; мэрийвэл сурч болно.*

МЭРМЭРХИЙХ аюулхайн тус газар жим жим хийж өчүүхэн өвдөх.

МЭРҮҮЛЭХ 1. мэрэхийн үйлдүүлэх хэв; 2. мэрэгдэх.

МЭРЭГЖИЛ урлаг, техник, шинжлэх ухааны аль нэг салбарыг голлож эзэмшсэн мэдлэг, чадвар; багшийн мэрэгжил; *мэрэгжлийн үнэмлэх.*

МЭРЭГЖИЛГҮЙ гол эзэмшсэн мэдлэг чадвар олоогүй.

МЭРЭГЖИЛТЭЙ гол эзэмшсэн мэдлэг чадвартай.

МЭРЭГЖИЛТЭН 1. мэрэгжил бүхий хүн; *Зөвлөлтийн мэрэгжилтэн нараас сурах;* 2. мэрэгжилтэй олон хүн; *мэрэгжилтэн нөхдөөс юм дуулах хэрэгтэй!*

МЭРЭГЖИХ гол эзэмшсэн мэдлэг чадвартай болох; *амин судлалаар мэрэгжих.*

МЭРЭГЖҮҮЛЭХ мэрэгжихийн үйлдүүлэх хэв; *ажилд мэрэгжүүлэх.*

МЭРЭГЛҮҮЛЭХ мэрэглэхийн үйлдүүлэх хэв.

МЭРЭГЛЭХ төлөг тавих.

МЭРЭГЧ I мэрэг төлөг үзэгч хүн.

МЭРЭГЧ (ИН) II хэрэм, тарвага, хулгана, оготно зэрэг, урт үүдэн шүдтэй, хөхөөр бойжигч амьтад.

МЭРЭГЧИД мэрэгч амьтад; *мэрэгчдийг устгах.*

МЭРЭГШИЛ аль нэг үйл ажилд тэнхцэх мэдлэг боловсрол ,бэлтгэл.

МЭРЭГШИЛГҮЙ аль нэг үйл ажилд тэнхцэх мэдлэг боловсрол бэлтгэлгүй буюу муу.

МЭРЭГШИЛТЭЙ мэрэгшил бүхий; *мэрэгшилтэй ажилчин.*

МЭРЭГШИХ мэрэгшил мэдлэг олох.

МЭРЭГШҮҮЛЭХ мэрэгшихийн үйлдүүлэх хэв.

МЭРЭХ 1. хатуу юмыг шүдээр хусан идэх; *яс мэрэх; хөлдүү тос мэрэх;* 2. үйл ажлыг бага багаар үйлдэх; *зүгээр суухаар мэрж суух;* 3. ш и л ж с э н үргэлжлэн нажидтай өвдөх; *өрөн дээр үргэлж мэрж байна.*

МЭС ирт зэвсгийн зүйл; *хутга мэс; ирт мэс;* ☆ **мэс засал** (анагаах ухааны мэсээр өвчнийг засах арга; *мэс засал хийлгэх);* **мэс засалч** (мэс засал хийдэг хүн); **мэс заслын тасаг** (өвчнийг мэсээр анагаах газар); **мэс заслын больниц** (мэс засал хийж эмчлэх эмнэлэг).

МЭСДЭХ мэсээр огтлох, бүлэх.

МЭСЛЭХ мэсдэх.

МЭТ 1. адил, шиг; *айсан мэт болох; тэр мэтээр ёсчлон хийх хэрэгтэй; энэ мэт явдал; шохой мэт юм; барс мэт эрээн; муур мэт хулгайч; хэлсэн хийсэн мэтээр үзэх;* 2. зэрэг; *хайч хутга мэтийн багаж хэрэгсэл; гэх мэт болно.*

МЭТГҮҮЛЭХ мэтгэхийн үйлдүүлэх хэв.

МЭТГЭР этгэр матигар.

МЭТГЭХ I үйл ажилд шамдан зүтгэх; *үйл мэтгэх.*

МЭТГЭХ II харилцан булаалдаж марган тэмцэх; *мэтгэж мэтгэж дийлсэнгүй.*

МЭТГЭЭ 1. шамдамгай, мэрийлттэй; 2. маргадаг зантай.

МЭТГЭЭЧ мэтгэдэг зантай, мэтгэх зантай, мэтгэмтгий.

МЭТИЙЛГЭХ мэтийхийн үйлдүүлэх хэв, мэтгэр болгох.

МЭТИЙХ мэтгэр болох.

МЭТЭР мөтөр.

МЭТЭРХҮҮ мэтчилэн.

МЭТЭЧЛЭН үүн шиг, түүн шиг; *энэ мэтчилэн; тэр мэтчилэн; гэх мэтчилэн.*

МЭХ 1. хуурах гэнэдүүлэх арга; **заль мэх** х о р ш.; *мэхэд автагдах;* 2. бөхийн унагаах арга; *бөхийн мэх; мэх хийх.*

МЭХГЭР 1. амьтны гэдэс хэвэл мэхийсэн нь; *гэдсээрээ мэхгэр;* 2. мэтгэр; *мэхгэр мод.*

МЭХИЙ 1. санаа нарийн, хөшүүн; 2. ичимтгий.

МЭХИЙДЭХ мэхийн учир зохисгүйдэх.

МЭХИЙЛГЭХ мэхийхийн үйлдүүлэх хэв, мэхгэр болгох.

МЭХИЙРЭХ мэхгэр болох.

МЭХИЙСХИЙ 1. баахан мэхийх; 2. хоёр гараа хавсарч бөхийн ёслох.

МЭХИЙХ 1. бие бөхийн толгой гудайх; *мэхийн ёслов;* 2. хүн амьтны гэдэс хэвлээ дотогш гатаж хонхойлгох; 3. үйл явдалд хичээнгүйлэн чармайх, мэрийх.

МЭХЛҮҮЛЭХ 1. мэхлэхийн үйлдүүлэх хэв, мэхлэхэд хүргүүлэх; 2. мэхлэгдэх.

МЭХЛЭГДЭХ мэхлэхийн үйлдэгдэх хэв, мэхэд автагдах.

МЭХЛЭСХИЙХ баахан мэхлэх.

МЭХЛЭХ залилах, хуурах, хуурамч зан гаргах; **залилах мэхлэх** х о р ш.; *учир мэдэхгүй хүмүүсийг мэхлэх.*

МЭХЛЭЭЧ мэхлэх зантай, мэхэлдэг зантай; мэхлэмтгий.

МЭХРЭХ 1. эрүүгээ хөдөлгөх; 2. чимээгүй инээх.

МЭХТ аргатай, овтой, мэхтэй, зальтай.

МЭХЧ мэх заль гаргагч.

МЭХЭЛЗЭХ мэхэс мэхэс хөдлөх.

МЭХЭРХИЙ хөлийн өсгий хуруу хоёрын хоорондох газар.

МЭХЭСХИЙЛГЭХ мэхэсхийхийн үйлдүүлэх хэв.

МЭХЭЭР бүүргэнэ гэдэг ургамлын үндэс, хүн иднэ; *хонин мэхээр; үхэр мэхээр.*

МЭЦ: мэц хорхой а м ь т а н сээр нуруутай амьтад болон хүний гэдсэнд бий болох шимэгч цагаан хорхой.

МЭЦГИЙ мэц хорхой.

МЭЧ (ИН) мич.

МЭЧИД з у р х а й мичид.

МЭШИЛ хараа зүйд хэрэглэдэг хотгор буюу гүдгэр гадрагатай шил буюу гунгалаг эдгэл шил; *хотгор мэшил.*

МЭЭТГЭР 1. тахир, этгэр; 2. эрүү урт, хамрын үзүүр том; *мээтгэр нүүртэй.*

МЭЭТИЙХ мээтгэр болох.

МЯГМАН нэгэн зүйл тоглоом, гурван зуун жаран ширээг, хоёр өнгийн юмаар тусгай хөлгөнд өрж хоёр хүн харилцан хаалцаж наадна.

МЯГМАР I долоо хоногийн хоёрдугаар өдөр; *Мягмар гариг онгоц нисна.*

МЯГМАР II нарны аймгийн нэг ертөнц.

МЯЛИА малиа.

МЯЛААЛГА мялаах үйлийн нэр; *гэрийн мялаалга.*

МЯЛААЛТ мялаасан нь.

МЯЛААХ 1. шинэ орд харш, гэр байшин зэргийг барьсан үчир хурим хийж найрлах; *гэр мялаах;* 2. шинэ хувцас хийж өмссөн хүүхэд багачуудад юм хум өгч баясгах; *дээлий нь мялаах.*

МЯЛАЙХ мялгар болох.

МЯЛАН мялзан.

МЯЛАНТАХ мялзантах.

МЯЛАНТУУЛАХ мялантахын үйлдүүлэх хэв.

МЯЛГА малиа.

МЯЛГАР хүний магнай милгэр, таваг савны зэрэг юмны амсар мялтгар зэргийн мялайн харагдах нь; *мялгар магнайтай, мялгар амсартай таваг.*

МЯЛЗАН үхрийн тахал өвчин.

МЯЛЗАНТАХ мялзан өвчин тохиох.

МЯЛТГАР 1. савын гүнзгий биш хавтгай; 2. хамар хавтгай.

МЯНГА (Н) тооны нэр, арван зуу; **мянга түм** (маш олон). **мянган түм** (арван зуун түм буюу арван сая эсвэл живаа).

МЯНГААД 1. мянга шахам, **мянга** орчим; 2. тус бүр мянга.

МЯНГАД монголын нэгэн аймгийн нэр,

МЯНГАТ мянга мянгаар хуваасан зохион байгуулалт.

МЯНДАГ буддын шашны ёсны эрдмийн зэрэг; *гавжийн мяндаг; аграмбын мяндаг.*

МЯНДАС (АН) ёнхор, хүр хорхойн ялгадсаар хийх утас; *мяндсан утас; мяндсан зөөлөн ноос.*

МЯНТУУЗ зуурсан гурилыг элдэж нимгэлэн нарийлж хэрчсэн нь; *мянтуузтай хоол.*

МЯНЧУУ нэгэн зүйл торгомсог бараа.

МЯО I арван мүү хэмжээтэй газар.

МЯО II х у у ч и р с а н сүм дуган.

МЯРААЛГАХ мяраахын үйлдүүлэх хэв.

МЯРААЛХИЙЛЭХ сэмээр гэтэлхийлэх мяраах.

МЯРААХ гэтэлхийлэн очих, гэтэж ойртох; *зэрлэг амьтан шиг мярааж явлаа.*

МЯРАЛЗАХ 1. сайхан инээх; *мяралзтал инээх;* 2. яралзтал; *мяралзтал урсах.*

МЯРАХ багажны ир уярч эмтрэн унах; *хутган ир мярах.*

МЯТАЛ мятарсан нь.

МЯТРАЛ мятрах үйлийн нэр.

МЯТРАЛГҮЙ шантралгүй.

МЯТРАХ 1. амьтны айх, бэрхшээх, зүрхших; *мятарч болохгүй, зоригтой ажилла!* 2. зарим юмны нугарагдан шантрах; *царил мятарч байна; хутга мятраад болохгүй байна.*

МЯТРАШГҮЙ 1. айх бэрхшээхийг мэдэхгүй 2. шантрахгүй бат дөжир юм.

МЯТРУУЛАХ матрахын үйлдүүлэх хэв, мятрахад хүргүүлэх.

Н

Н гийгүүлэгч үсэг, гийгүүлэгч авиа.

НААГДАХ наахын үйлдэгдэх хэв.

НААГУУР 1. юмны наад талаар, наад этгээдээр; *уулын наагуур; замын наагуур; наагуур яв!* 2. ш и л ж с э н мөчид, даамай биш, хуумгай; *наагуур бодох;* **наагуур хүн** (хуумгай хүн).

НААГУУРДАХ 1. дэндүү наагуур болох; 2. ш и л ж с э н хуумгайдах.

НААГУУРДУУЛАХ наагуурдахын үйлдүүлэх хэв, наагуурдахад хүргүүлэх.

НААГУУРЛАХ юмыг хөнгөн хуумгайгаар авч үзэх.

НААГУУРХАН арай наагуур.

НААГУУРХИЙХ бусдыг ойшоон хүндэтгэж үзэхгүй, хөнгөнд үзэх.

НААД янад, энэтээ; *хотын наад этгээдэд бий; голын наад захад оршино.*

НААДАГ бусдад нялганан ойртохдоо сурамгай *наадаг хүн нааж л яваа биз.*

НААДАЛ I тоглоом, наадам; *наадал хийх; наадал болгох.*

НААДАЛ II наасан газар; *авдрын наадал; наадлаараа салах.*

НААДАЛДАХ наадахын хамтран үйлдэлдэх хэв.

НААДАМ 1. олноороо хийж бясах цэнгэл зугаа; **найр наадам, баяр наадам** х о р ш.; *сумын наадам; аймгийн наадам; улсын наадам; овооны наадам; наадмын морь; наадмын бөх; наадмын сур;* **эрийн гурван наадам** (морь уралдах, бөх барилдах, сур харвах наадам): 2. тоглоом; **тоглоом наадам** х о р ш.; **наадам хийх** (а. зугаа цэнгэл хийх; б. тоглоом доог хийх); **наадам болгох** (доог тохуу хийх).

НААДАМЧ 1. наадам тоглоомд дуртай; 2. алиа хошинч.

НААДАМЧИН наадам хийж явагчид, наадамд ирж цэнгэгчид, наадам сонирхогчид.

НААДАХ 1. тоглох; **наадах цэнгэх, тоглох наадах** х о р ш.; *бөмбөг наадах; тайзан дээр наадах; мөсөн дээр гулгаж наадах; чулуугаар наадах;* 2. наадам хийж цэнгэх; *сайхан наадаж байна уу?.*

НААДАХЬ 1. наад тал, энэтээ этгээд; *уулын наадахь хажуу; голын наадахь эрэг дээр;* 2. энэ этгээд; *наадахь чинь чингэж хэлсэн; наадахийгаа дууд!.*

НААДГАЙ I наадах юм, хүүхэлдэй.

НААДГАЙ II наазгай, аажим, удаан, тайван; *төрөлхийн наадгай хүн.*

НААЗГАЙ цалгар залхуу, дэндүү аажим; **цалгар наазгай, залхуу наазгай** х о р ш.

НААЗГАЙДАХ дэндүү наазгай болох, алгуурдах, цалгардах, удаадах.

НААЗГАЙРАХ наазгай болох; *чи битгий наазгайраад бай! наазгайрвал цаг алдахад хүрнэ.*

НААЛГАХ наахын үйлдүүлэх хэв, наахад хүргүүлэх.

НААЛДАГДАХ наалдахын үйлдэгдэх хэв.

НААЛДАМТГАЙ наалдамхай.

НААЛДАМХАЙ наалддаг, наалдахдаа сайн; *гарт наалдамхай эд; бусдад наалдамхай зантай хүн.*

НААЛДАНГИ сайн наалддаг, наалдах нь сайн.

НААЛДАНГИР наалдамтгай юм; *давирхай бол наалдангир зүйл; наалдангир шавар.*

НААЛДАНГИРАХ наалдангир болох.

НААЛДАНГИРТАХ наалдангир байдалтай болох.

НААЛДАНГИРШИХ наалдангир шинжтэй болох.

НААЛДАХ 1. юманд барилдан зууралдаж тогтох; *цонхны цаас сайн наалджээ; гарт давирхай наалдав; дээлд үс наалдсан байв;* 2. юманд шахагдан тулж байх; *туурганд наалдан зогсов;* 3. ш и л ж с э н дотнолон ойртож салахгүй байх; *хэнтэй л бол наалдаж явдаг хүн.*

НААЛДАЦ наалдах чадал, наалдахуй чанар; *наалдац сайтай; наалдац муутай.*

НААЛДУУЛАХ 1. наалдахын үйлдүүлэх хэв; 2. наалдагдах.

НААЛДУУР 1. дэлүү; 2. ялаа наалдуулж устгах юм, ялааны хор; 3. шувуу наалдуулж барих хэрэглэл.

НААЛИНХАЙ I эелдэг хөөрхөн ааштай; *наалинхай зантай хүүхэд; наалинхай амраг чамайгаа, насны юм шиг эндүүрэв* (ардын *дуу*).

НААЛИНХАЙ II хоёр далавчит жижигхэн хорхой.

НААЛИНХАЙДАХ дэндүү наалинхай болох.

НААЛИНХАЙРАХ наалинхай байдал үзүүлэх.

НААЛИНХАЙРУУЛАХ наалинхайрахын үйлдүүлэх хэв.

НААЛИНХАЙТАХ наалинхай зан гаргах.

НААЛИНХАЙТУУЛАХ наалинхайтахын үйлдүүлэх хэв.

НААЛТ I юмны наасан газар; *наалтаараа ховхрох.*

НААЛТ II малын дэлүү.

НААМАЛ нааж хийсэн юм; *наамал ул; наамал банз ;наамал гутал.*

НААНА 1. энэ талд, энэтээ, энд, дэргэд; *голын наана; чиний наана; наана чинь хэн байна? наанаа үз! наанаасаа хар;* **наана цаана болох** (сандран самгардах); **та минь наана** (намайг авраач, над туслаач!); **амь наана, там цаана** (маш их сандарч тэвдсэн байдал); 2. дотор, янар; *энэ сарын хорины наана; улсын их хурлын наана.*

НААНАДАХ 1. дэндүү наана болох; 2. ш и л ж с э н наанадаа; **наанадаа** (адаглахдаа); *наанадаа нэг долоо хоног болно.*

НААНАДУУЛАХ наанадахын үйлдүүлэх хэв, наана болгох.

НААНГИ наалдаа шороо; *наанги шавар; наанги шороо;* **наанги зангуу** у р г а м а л (зэллэн ургана, бяцхан навчтай, хушуутай үртэй, өргөстэй нэгэн зүйл ургамал); **наанги цагаан** у р г а м а л үр нь зэлэнд буурцаг мэт ургана, үндэс ба буурцгийг чанаж иддэг нэгэн зүйл ногоо); **наанги чавга** у р г а м а л (уд модны навчтай адил навчтай модонд ургадаг нэгэн зүйл жимс, янз байдал гүйлсийн адил); **наанги сэрүүн боорцог** (амууг жигнэн хийсэн идээ).

НААНГИНЦАР наалдаа наанги байдалтай; *наангинцар шавар элс.*

НААХ 1. цавуу жонхуу мэтээр юмыг авцалдуулах, барилдуулах; *захидлын дугтуйг наах; цавуугаар наах;* 2. хүний бусдад ялмагалзан нийлүүлж явах; **наах эм** (өвчин эмгэнийг хөхүүлэн соруулахад зориулан хийсэн гоюу мэтийн зүйл).

НААХНА арай наана, ойрхон; *чиний наахна бий; байшингийн наахна сууж байна.*

НААШ 1. цаашийн эсрэг утга, өөрийн тал руу, өөрийн талд; *наашаа суу! наашаа ирэх; нааш нь авчрах; наашаа харах; хөлөө нааш нь жийх;* **нааш харахгүй** (тус дэмжлэг болох шинжгүй); **нааш харах ах дүү** (тус дэмжлэг болох хүмүүс); **намайг нааш харах цаг боллоо** (намайг тэтгэх туслах цаг болов); **наашаа болох** (а. ойртох, дөтлөх; б. баахан ялаар бодох; в. бүтэх төлөв орох); **нааш нь татах** (а. өөрийн тийш татах; б. үнийг бууруулах); **нааш цаашгүй** (хөдөлгөөгүй); **нааштай цааштай** (өгөө аваатай, тохирч болмоор, уян хатан хөдөлгөөтэй); 2. дотогш, дотор; *сараас нааш ирэхгүй; зуугаас нааш өгөхгүй; хориноос нааш ирнэ;* 3. наана, үгүй бол; *чамайг өгөхөөс нааш явахгүй; ажил хийхээс нааш бүтэхгүй; би үзэхээс нааш итгэхгүй; хүн сайн ч бол хэлэхээс нааш санахгүй, цаас нимгэн ч бол чичихээс нааш цоорохгүй* х у у ч.

НААШДАХ дэндүү нааш болох; *тэр ор чинь наашдасан байна.*

НААШДУУЛАХ наашдахын үйлдүүлэх хэв.

НААШЛАХ 1. наашаа болох, ойртох; *наашилж явна;* 2. буурах; *үнэ наашлах;* 3. ялаарших; *өвчин наашлах төлөвтэй.*

НААШЛУУЛАХ наашлахын үйлдүүлэх хэв, нааш нь болгох.

НААШРАХ нааш ирэх, нааш хүрч ирэх; *наашрахгүй юү? чи.*

НАВС ш а ш и н 1. бумбаны өмсгөл; 2. хувцасны хүндэтгэл; *бурхны навс.*

НАВСАЙЛГАХ навсайхын үйлдүүлэх хэв.

НАВСАЙХ навсгар болох; *дах шиг цув өмсөөд навсайж явав.*

НАВСАЛЗАХ навсгар юмны навсас навсаа хөдлөх.

НАВСАЛЗУУЛАХ навсалзахын үйлдүүлэх хэв.

НАВСАС: навсас навсас хийх навсгар юмны байн байн хөдлөх байдал.

НАВСГА: навсга навсга хийх навсгар юмны үргэлжлэн хөдлөх.

НАВСГАНАХ 1. навсгар юмны навсга навсга хөдлөх; 2. ш о о д с о н дэмий дагаж гүйх, өөрэх, хоргоох; *тэр түүнийг дагаад л навсганаж явна; ер нь ч навсганадаг зантай хүн дээ.*

НАВСГАНУУЛАХ навсганахын үйлдүүлэх хэв.

НАВСГАР 1. энд тэндээ унжиж навсарсан хөглөсөн, урагдаж салбарсан юм; **навсгар нэвсгэр** х о р ш.; *навсгар цув; навсгар гэр;* 2. ш о о д с о н элбэгдсэн томдсон хувцас.

НАВСГАСХИЙХ юмны гэнэт навсга навсга хийж хөдлөх.

НАВТАЙЛГАХ навтайхын үйлдүүлэх хэв, навтгар болгох.

НАВТАЙХ навтгар болох; **навтайх хавтайх** х о р ш.; *намхан хаалгаар навтайн оров.*

НАВТАЛЗАХ навтгар юмны навтас навтас хөдлөх; *морины нуруу навталзаж байв.*

НАВТАР навтгар.

НАВТАРХАЙ сэмрэн урагдсан, навтарсан нь; **уранхай навтархай** х о р ш.; *навтархай исгий; навтархай данс.*

НАВТАС I уранхай, нооронхой исгий, хөдөс; **исгий навтас, навтас хөдөс** х о р ш..

НАВТАС II **навтас навтас хийх** навтгар юмны байн байн хөдлөх байдал.

НАВТАС III адгуус амьтны ихэс.

НАВТАСХИЙХ гэнэт доош болон бөхийх, тонгойх; *хулгайчийн толгой дээр гал гэхэд навтасхийв* д о м о г.

НАВТГА: навтга навтга хийх навтгар юмны үргэлжлэн хөдлөх байдал.

НАВТГАНАХ навтгар юмны навтга навтга хөдлөх.

НАВТГАНУУЛАХ навтганахын үйлдүүлэх хэв.

НАВТГАР намхан, балтгар, навхгар; *навтгар нуруутай хүн; навтгар хад.*

НАВТГАРДАХ хэтэрхий навтгар болох.

НАВТГАРДУУЛАХ навтгардахын үйлдүүлэх хэв.

НАВТРАГ бичгийн үүсгэн зохиосон ноорог, цоохор; *бичгийн навтраг.*

НАВТРАХ үлэмж урагдах, сэмрэх; *хуучирсан хувцас нь навтран урагдав.*

НАВХАЙЛГАХ навхайхын үйлдүүлэх хэв, навхгар болгох.

НАВХАЙХ навхгар болох.

НАВХАЛЗАХ навхгар юмны навхас навхас хөдлөх.

НАВХАС: навхас навхас хийх навхгар юмны байн байн хөдлөх.

НАВХГА: навхга навхга хийх навхгар юмны үргэлжлэн хөдлөх байдал.

НАВХГАНАХ навхгар юмны навхга навхга хөдлөх.

НАВХГАНУУЛАХ навхганахын үйлдүүлэх хэв.

НАВХГАР намхан, балтгар, навтгар; *навхгар гэр; навхгар хүзүү; навхгар ширээ.*

НАВЧ (ИН) 1. ургамлын агаар тэжээл ба хийн солилцооны эрхтэн, голдуу нимгэн хавтгай хэлбэртэй, ногоон өнгөтэй байна; **навч нахиа** х о р ш.; *модны ногоон навч;* **навчин алт** (нимгэлэн давтсан алт); **навчин тамхи** (нүдэж талхлаагүй, навч хэвээр байгаа тамхи); **навчин боорцог** (а. навчинд жигнэж болгосон нэг зүйл идээ; б. гурил амтаны зүйлийг үе үеэр давхарлан тавьж хийсэн нэгэн зүйл нарийн боов, печень); 2. чихний ёгт нэр; **навчинд бараалхах** (чихдэх).

НАВЧГАР хамшгар, шамшгар, навчийсан нь.

НАВЧИЙЛГАХ навчийхын үйлдүүлэх хэв, навчгар болгох; хадаасны толгойг *навчийлгасан байна билээ.*

НАВЧИЙХ навчгар болох; *дугуйд дайраг-дан навчийсан лааз.*

НАВЧИРХАГ навч ихтэй.

НАВЧИРХУУ 1. навч ихтэй; 2. навч мэт.

НАВЧИТ навч бий; *навчит мод; навчит ой;* **навчит хуудас** (эвхмэл цаасанд хатуу гадар хийж түүн дээр зураг зурж, бичиг бичсэн нь); **навчит өргөмжлөл** (хатуу гадар тавьж хийсэн өргөмжлөл бичиг).

НАВЧЛАХ навч ургах, навч гарах; *хус мод навчлах.*

НАВЧЛУУЛАХ навчлахын үйлдүүлэх хэв.

НАВШ жац: **навшийн спирт** (жацын спирт).

НАВШАА лавшаа; *навшаа хурга; навшаа хүүхэд.*

НАВШГАР налжгар, навчгар бяцхан, намхан; *навшгар хамар*

НАВШИЙЛГАХ навшийхын үйлдүүлэх хэв, навшгар болгох.

НАВШИЙХ навшгар болох.

НАВШИХ хэтэрхий хөхөх; *ишиг навших.*

НАГА: нага цэцэг у р г а м а л өнгө цагаан, зургаан хэлтэстэй, шар туурцагтай, навчгүй нэгэн зүйл цэцэг.

НАГАЙ эм тарвага.

НАГАЛ нахайд ургасан сахал.

НАГАН нэг зүйл гар буу.

НАГАС: нагас нагас хийх 1. бусдад элэгсэг байдал гаргах; 2. яаран тэвдэх байдал гаргах.

НАГАЦ эхийн төрлийн хүмүүс; **нагац эцэг** (эхийн эцэг); **нагац эх** (эхийн эх); **нагац ах** (эхийн ах дүү); **нагац эгч** (эхийн эгч дүү); бага нагац (эхийн дүү нар); **зээ нагац** (эхийн ах нар); **их нагац эгч** (эхийн эгч); **бага нагац эгч** (эхийн охин дүү).

НАГВАН бэхний сав.

НАГЖГАР богино, навтгар; *нагжгар хүзүү; нагжгар ширээ.*

НАГЖИЙЛГАХ нагжийхын үйлдүүлэх хэв, нагжгар болгох.

НАГЖИЙХ нагжгар болох.

НАГТАХ нааландангир болж өтгөрөх; **нааладах нагтах** х о р ш.; *тагнайд гурил нагтах; хоол нагтчихжээ.*

НАГТУУЛАХ нагтахын үйлдүүлэх хэв.

НАГЧИРХАЙ сээр нуруутан амьтад болон хүний хамрын нүхний дотоод сүв.

НАД миний бие; *над хэрэгтэй ном; над өгөөч; над алга; тэгвэл ч над бүр сайн шүү; надаар юм явуулсан; чи надаар яах гэсэн юм бэ?; надаас авлаа; надаас гарсан хэрэг биш; надад хэлэх юм алга байна; надтай хамт яваарай; надтай ярьсны хэрэггүй.*

НАДАР: надар садар 1. нүсэр үлэмжийн байдалтай; *надар садар ачаа чүцээ;* 2. хойно хоцорч дараа дараагаар цуварсан нь; *надар садар ирэх.*

НАЖ: наж могой а м ь т а н халуун оронд орших хорт могой, уурлавал толгой тал буюу бүх биеийн гурабны нэг нь өндийн босч хүзүү этгээд нь чинэж бүдүүрнэ.

НАЖИГНАХ 1. хүчтэй чимээ гарах; *хүн суухад эвдэрхий сандал нажигнан дуугарав; тэнгэр нажигнах;* **нажигнах нэжигнэх** х о р ш.; 2. шаламгайлах, гавшгайлах; *нажигнасан залуу шүү.*

НАЖИГНУУЛАХ нажигнахын үйлдүүлэх хэв.

НАЖИД зовлон, бэрхшээл; *нажид болох.*

НАЖИДЛАХ зовлон бэрхшээл учруулах, зовоох.

НАЖИДТАЙ зовлонтой, бэрхшээлтэй; *над нажидтай хэрэг тохиолдов.*

НАЗГАЙ наазгай, цалгар, хичээнгүй биш, залхуу: **цалгар назгай** х о р ш..

НАЗГАЙДАХ хэтэрхий назгай байх, цалгардах.

НАЗГАЙДУУЛАХ назгайдахын үйлдүүлэх хэв.

НАЗГАЙРАХ назгай болох; *назгайрч байгаад цагаас хожимджээ.*

НАЗГАЙРУУЛАХ назгайрахын үйлдүүлэх хэв, назгай болгох.

НАЗГАЙТАХ назгай байдал гаргах.

НАЗГАЙТУУЛАХ назгайтахын үйлдүүлэх хэв.

НАЗГАЙШРАХ назгайн шинжтэй болох.

НАЙ найралдаж маш итгэлцсэн нь; ***най болсон хүн; ний найгүй итгэсэн нөхөр;*** **най найрал, най самс** х о р ш.; **най хуур** (баруун гартаа төгөлдөр хуурын даралт бүхий нэг зүйл баян хуур, аккордеон).

НАЙГАЛЗАХ 1. юмны нахилан нахилж эетэй сайхан хөдлөх; *найлзуур модны нахилан найгалзах нь хичнээн сайхан бэ!* 2. ганхалзах.

НАЙГАЛЗУУЛАХ найгалзахын үйлдүүлэх хэв, ганхалзуулах.

НАЙГАЛТ I найгах үйлийн нэр, ганхалт.

НАЙГАЛТ: найгалт цэцэг у р г а м а л бут бутаар ургана, цэцэг нь дөрвөн хэлтэстэй, хошоочин цэцэглэнэ, иш нь маш уян, салаа нарийн, сэлхигүй боловч гулжилзана.

НАЙГАХ ганхах; **найгах ганхах, найгах гуйвах** х о р ш.; *салхинд өвс найгах; бусдад уруу татагдан найгах хэрэггүй.*

НАЙГУУЛАХ найгахын үйлдүүлэх хэв, найгахад хүргүүлэх, ганхуулах, гуйвуулах.

НАЙГҮЙ хамгийн муу, авах хэрэглэх аргагүй; *найгүй муу мал; найгүй муухай амьтан.*

НАЙДАЛ найдах үйлийн нэр, итгэл; *найдал тасрах.*

НАЙДАЛТАЙ найдал бүхий, итгэл бүхий, найдвал зохих зүйл байгаа, найдаж болох нь.

НАЙДАЛЦАХ найдахын үйлдэлцэх хэв, үйл явдлыг харилцан найдах, түлхэлцэх; *хоёр биедээ найдалцаар тасалдуулав.*

НАЙДАМТГАЙ бусдад найддаг зантай.

НАЙДАМХАЙ найдамтгай.

НАЙДАНГУЙ 1. найдамтгай зантай; 2. атаа; *найдангуй сэтгэл төрөх.*

НАЙДАНГУЙЛАХ 1. найдангуй байдал гаргах; 2. атаархах.

НАЙДАНГУЙРАХ 1. найдангуй болох; 2. атаарах.

НАЙДАХ 1. итгэх; хүнд найдаж болох зүйл; **итгэх найдах** х о р ш.; *би бат найдаж байна;* 2. дашуурах, түлхэлцээ хийх; *би түүнд найдаад ийм болов; дулийдээ найдаж унгарах* х у у ч.

НАЙДВАР найдлага, итгэл; **итгэл найдвар** х о р ш.; *найдварыг хангаж чадна.*

НАЙДВАРГҮЙ итгэлгүй, итгэх найдах аргагүй; *найдваргүй этгээд.*

НАЙДВАРЛАХ найдах, найдвар тавьж итгэх.

НАЙДВАРТАЙ итгэлтэй, итгэвэл зохих зүйл бий; *найдвартай хэрэг; найдвартай байж болно; найдвартай тулгуур.*

НАЙДЛАГА найдвар, итгэмж; *найдлагатай томоотой хүн; найдлага горьдлогогүй болсон гэж бодов.*

НАЙДЛАГАГҮЙ найдах итгэхийн арга байхгүй, найдлага тасарсан нь; *найдлагагүй юмыг харж суугаад юугаа хийх вэ.*

НАЙДЛАГАТАЙ итгэх найдах үндэс бүрэн бий, итгэлтэй.

НАЙДУУЛАХ найдахын үйлдүүлэх хэв, найдахад хүрүүлэх.

НАЙЖ анд бололцсон эмэгтэйчүүд харилцан бие биенийгээ ийнхүү дуудна.

НАЙЗ харилцан дотно нөхөрлөсөн нь; *найз нөхөд; миний найз; найз ахай.*

НАЙЗАРХАГ найз сайтай; *найзархаг хүнтэй нөхөрлөхөд сайхан.*

НАЙЗАРХАХ дотночлон нөхөрлөснөө бах болгох, найзархаг байдал гаргах.

НАЙЗАРХУУ найзархаг.

НАЙЗЛАХ дотночлон нөхөрлөх; *би түүнтэй найзлах маш дуртай байна.*

НАЙЗЛУУЛАХ найзлахын үйлдүүлэх хэв.

НАЙЛАНХАЙ I а м ь т а н батганатай адил болоод маш бяцхан, элдэв хог буртагт төрөх нэгэн зүйл ялаа.

НАЙЛАНХАЙ II элдэг хөөрхөн зан; *найланхай зантай хүүхэд.*

НАЙЛАНХАЙДАХ хэтэрхий найланхайн учир тохиромжгүй болох.

НАЙЛАНХАЙРАХ найланхай болох; *чи битгий найланхайраад бай!*

НАЙЛАНХАЙРУУЛАХ найланхайрахын үйлдүүлэх хэв.

НАЙЛАНХАЙТАХ найланхай зан байдал гаргах.

НАЙЛАНХАЙТУУЛАХ найланхайтахын үйлдүүлэх хэв.

НАЙЛЗУУР мод, өвсний мөчир, нарийн үзүүр; *модны найлзуур.*

НАЙЛЗУУРХАЙ гэдэс дотрын тунгалгийн булчирхай; **долоон булчирхай, найман найлзуурхайгаа тоочих** (нуух хаахгүй илэн далангүй ярих).

НАЙМ (Н) тооны нэр, долоо дээр нэгийг нэмсэн нь; *тав гурвын найм; найм дахин өсгөх; найман зуун тавь; гуравдугаар сарын найман; эр хүн долоо дордож найм сэхнэ* з ү й р: **Найман аймаг** (эртний нэгэн монгол аймгийн нэр); **Найман хушуу** (Өвөр монголын нэгэн хушуу).

НАЙМАА маймаа; **арилжаа наймаа** х о р ш.; *юу наймаалж байна? наймаа сайн уу? наймаа таарах; гутлын наймаа хийх үү?*

НАЙМААД 1. тус тус найм; 2. найм орчим.

НАЙМААЛАХ маймаалах, худалдаалах; *цув наймаалах санаатай байна.*

НАЙМААЧ (ИН) наймаа хийх ажлыг гол болгосон хүн; *наймаач хүн найман мэхтэй.*

НАЙМАЛЖ а м ь т а н усанд төрнө, дүгрэг биетэй, нээлхийтэй, хоёр хавчуур, найман хөлтэй, хөндлөн явдаг нэгэн зүйл хорхой.

НАЙМАЛЗАРГАНА а м ь т а н хүний үсэрхэг газар бий болдог нэг зүйл бөөс, биеийн урт нь 1—1,5 мм. хүний биед шигдэх нь сүрхий бөгөөд их загатнуулна.

НАЙМДУГААР наймд тохиолдсон нь; *наймдугаар сар; наймдугаар үе; наймдугаар зүйл.*

НАЙМТ 1. найм хуваасны нэгийн хэмжээ; *наймт цаас;* 2. найман тоо бүхий юм; *гил харын наймт;* 3. найман наст; *чи ямар арван наймт биш дээ.*

НАЙМУУЛ найман тоотой юм хамт; *бид наймуул ирэв; наймуул үүрэг авсан.*

НАЙМХАН дөнгөж нэйм, наймын төдий; *би наймхан төгрөгтэй.*

НАЙР I 1. эе, эв; *найртай сайн харилцаа тогтоох;* **найр харах** (эе эв харах, нүүр харах); 2. тал, зохирол; **найр тавих, найр өгөх** (ямар нэг юмыг тал нүүр харж, өөрийн ашиг тусыг бодож буулт үзүүлэх); **найр засах** (тал засах); **найрт салхи** (дөлөөн салхи).

НАЙР II хурим, цэнгэл, наадам: **найр наадам, найр хурим, найр хөөр, найр цэнгэл** х о р ш . ; *найр хийх; найрт оролцох; наян тавны найр; найр хөөр болох; ная хүрсэн настангууд, найран дундаа найгаж байна* (ардын дуу); ☆ **хайр найргүй** (хайрлан харамсах сэтгэлгүй).

НАЙРАГ ямар нэгэн юмны хольцоод багтсан зүйлс; *химийн найраг; эмийн найраг* ☆ **яруу найраг** (айзам хэмжээнд тохируулан зохиосон шүлгийн зохиол); **найраг дуу** (хөгжимчдийн хамт хэсэг бүлгээр дуулах дуу); **дан найраг дуу** (дан дуучид хэд хэдэн хоолойгоор дуулах дуу).

НАЙРАГЛАЛ шүлэглэн бичсэн том зохиол; *«Хүрэн морь» гэдэг найраглал.*

НАЙРАЛ эв, найр; **эв найрал, найр найрал** х о р ш.; *найралтай; найралгүй;* **найрал хөгжим** (янз бүрийн хэгжмөөр хамтран хөгжимдөгч бүлэг хөгжимчид; *яруу тунгалаг найрал хөгжим; чавхдаст найрал хөгжим; үлээвэр найрал хөгжим*).

НАЙРАЛДАХ 1. найрахын үйлдэлдэх хэв, найртай болох, зохирох, зохицох, эвлэрэх; 2. олон юм хоорондоо нийцэж найрах.

НАЙРАЛДУУЛАХ найралдахын үйлдүүлэх хэв

НАЙРАЛХАГ 1. найр сайтай, найрсаг зантай; 2. найрт дуртай.

НАЙРАЛХУУ найралхаг.

НАЙРАМДАЛ найрамдах үйлийн нэр, эв найрал, харилцан сайн байх харьцаа; *найрамдал байгуулах; Монгол-Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэг;* **эв найрамдал** х о р ш . .

НАЙРАМДАЛТ найрамдал байгуулсан нь; *манай найрамдалт Зөвлөлт Холбоот Улс; найрамдалт нөхөр.*

НАЙРАМДАЛТАЙ найрамдал бүхий, найрсаг харилцаатай; *эв найрамдалтай байх хэрэгтэй.*

НАЙРАМДАХ харилцан сайжрах, эв нэйртай сайн харилцаатай болох; *хоёр улс хоорондоо найрамдав; бүгд найрамдах улс; Бүгд Найрамдах Монгол Ард Улс.*

НАЙРАМДУУ хөнгөмсөг эвлэгхэн зантай; *найрамдуу ёс.*

НАЙРАХ 1. найралдах, хоорондоо найралдан нийцэх; 2. шагаа наадах; 3. ш и л ж с э н санаа зохицон нийцэх; **найрах найрамдах** х о р ш . .

НАЙРГҮЙ эвгүй, нийцгүй, найрамгүй.

НАЙРЛАГА юмны бүтсэн хольц, бүтэц; *химийн найрлага; эмийн найрлага; найрлагыг мэдэх; найрлагыг олох;* **найрлага зүй** (хэлний найрлага судлах ухаан).

НАЙРЛАХ 1. найр хийх, найр болох; *ид ажлын үеэр найрлаж болохгүй;* 2. найрч нийцэх.

НАЙРЛУУЛАХ 1. найрлахын үйлдүүлэх хэв; 2. найруулах, нийцүүлэх.

НАЙРСАГ найртай, элэгсэг; *найрсаг зочолт.*

НАЙРТАЙ найр бүхий, эе эвтэй, элэгсэг хөнгөмсөг байдалтай; *найртай сайхан байдалд болж өнгөрөв; найртай хөрш улс.*

НАЙРУУ эетэй, аятайхан зан байдалтай; *найруу зантай хүн.*

НАЙРУУЛАГЧ 1. жүжиг киног зааварлан тоглуулагч; *театрын найруулагч; кино найруулагч;* 2. галт тэрэгний бүрэлдэхүүнийг зохион тохируулах мэрэгжилтэй ажилтан; *галт тэрэгний найруулагч;* 3. юмыг хооронд нь нийцүүлэн тохируулагч; *эм найруулагч; хоол найруулагч;* 4. бичиг зохиолыг зохиогч, бусдын зохиосон зүйлийг хянан засагч; *зохион найруулагч; хянан найруулагч.*

НАЙРУУЛАМЖ найруулсан төлөв, байдал, төрх; *энэ зохиолын найрууламж маш сайхан болсныг тэмдэглүүштэй.*

НАЙРУУЛАХ 1. хооронд нь тохируулан бүрэлдүүлэх; *эм найруулах; архи найруулах; хор найруулах; буузны махны нөөө давсыг найруулан таарууллах;* 2. зохиол бичиг зэргийн үг утгыг эвтэй тохиромжтой болгох; *бичиг найруулах; үг үсгийг найруулан засварлах;*

3. *жүжиг*, киног зааварлан тоглуулах; *жүжиг найруулах;* 4. галт тэрэгний бүрэлдэхүүнийг тохируулан бэлтгэх; *галт тэрэг найруулах.*

НАЙРУУЛГА найруулах үйлийн нэр; **хэлний найруулга** (тухайн хэлээр санаа бодол, утга тэргүүтнийг зөв илрүүлэн гаргах аргын цогц; *найруулга сайтай; найруулга муутай*).

НАЙРУУЛУУЛАХ найруулахын үйлдүүлэх хэв.

НАЙРЧ (ИН) 1. найрт дуртай; **найрч хөөрч** х о р ш.; 2. найрт оролцогсод; *найрчин явцаажж байна.*

НАЙТААЛГА найтаах үйлийн нэр.

НАЙТААЛГАХ 1. найтаахын үйлдүүлэх хэв; 2. найтаах.

НАЙТААХ өөрийн эрхгүй бие давхийн хөдлөхийн хамт дуугарч шүлс үсэргэн хамар амаар амьсгал гаргах.

НАЛ: нал эрдэнэ улаан өнгөтэй нэг зүйл эрдэнийн чулуу, гоёл чимэглэлийн зүйлд хэрэглэнэ.

НАЛАЙ: налай далай өргөн их юм, нэлий ч гэдэг.

НАЛАЙЛГАХ налайхын үйлдүүлэх хэв, налгар болгох.

НАЛАЙХ налгар болох; *налайсан сайхан өдөр байна; хонь маань налайтал билчиж байв.*

НАЛАМГАР саламгар, нэлэмгэр; *наламгар исгий; наламгар бүрээс.*

НАЛАНГИ налуу, унанги.

НАЛАРХАЙ налуу, налсан, босоо биш, хэвтээ.

НАЛАХ 1. биеийг хажуу тийш болгон юм түших; *гэдрэг налж суух; хашаа налах;* 2. хазайх; ханарах; *налж унах; хашаа салхинд налчихжээ;* 3. хөлбөрөх, хөрвөх, *тэмээ үнсэн дээр налав.*

НАЛГАЙ налгар.

НАЛГАР 1. намуун аажим, удаан хөдөлгөөтэй, тайван; *налгар хүн;* 2. назгай, цалгар; *налгар цалгар нь хэтэрсэн амьтан;* 3. дулаан тогтмуун, тааламжтай, *налгар сайхан өдөр;* 4. тавиун сайхан; *налгар газар.*

НАЛДАА нуршин нялцгар юм; *налдаа цэр; налдаа шавар; налдаа шороо.*

НАЛДАЙЛГАХ налдайхын үйлдүүлэх хэв, налдгар болох.

НАЛДАЙХ налдгар болох, навтайх; *налдгар биетэй.*

НАЛДГАР намхан, богино, тагдгар.

НАЛИНА нэг зүйл лянхуа.

НАЛИХ 1. бусдад ялмагалзан явах; *түүний налих нь хэцүү;* 2. хов зөөх; *наашаа нальж, цаашаа цалих.*

НАЛМАГАНАХ налмагар юмны налмага налмага хөдлөх.

НАЛМАГАНУУЛАХ налмаганахын үйлдүүлэх хэв.

НАЛМАГАР салмарч урагдсан ноороихой юм; *налмагар хувцас; налмагар исгий;* **наламгар нэлмэгэр** х о р ш..

НАЛМАЙХ наламгар болох.

НАЛМАЛАХ налмаруулах, наламгар болгох.

НАЛМАЛЗАХ наламгар юмны налмас налмас хөдлөх.

НАЛМАЛЗУУЛАХ налмалзахын үйлдүүлэх хэв.

НАЛМАРАХ налмагар болох, урагдаж ноорох.

НАЛМАРУУЛАХ налмарахын үйлдүүлэх хэв.

НАЛМАРХАЙ налмагар болсон юм; *дээлийн налмархай.*

НАЛМАХ 1. налмарах, урагдах; 2. хээ хэншгүй байдал гаргах.

НАЛМИГАНАХ налмигар юмны налмига налмига хөдлөх.

НАЛИМГАР 1. маш зөөлөн, дорой мэт байдалтай; *налмигар малгай; налмигар цув;* 2. налмагар, нэлмэгэр.

НАЛМИГАРДАХ дэндүү налмигарын учир тохиромжгүй болох.

НАЛМИЙЛГАХ налмийхын үйлдүүлэх хэв, налмигар болгох.

НАЛМИЙХ налмигар болох.

НАЛМИЛЗАХ налмигар юмны налмис налмис хөдлөх.

НАЛМУУЛАХ налмахын үйлдүүлэх хэв.

НАЛУУ ташуу хэюү; *налуу ширээ; налуу ус; налуу дэл; налуу газраар машинтай явав.*

НАЛУУДАХ дэндүү налуугийн учир тохиромжгүй болох.

НАЛУУЛАХ налахын үйлдүүлэх хэв, налуу болгох.

НАЛУУР налдаг түшдэг юм; **түшлэг налуур** х о р ш.

НАЛУУХАН арай налуу.

НАЛХАЙЛГАХ налхайхын үйлдүүлэх хэв.

НАЛХАЙХ налхгар болох.

НАЛХГАР залхуу, алхгар, хөдөлгөө муутай.

НАЛЦАЛЗАХ намалзах, хотолзох.

НАЛЧГАНАХ налчгар юмны налчга налчга хөдлөх.

НАЛЧГАНУУЛАХ налчганахын үйлдүүлэх хэв.

НАЛЧГАР намхан, навтгар; ***налчгар хамар; налчгар сандал.***

НАЛЧИЙЛГАХ налчийхын үйлдүүлэх хэв, налчгар болгох.

НАЛЧИЙХ налчгар болох.

НАЛЧИЛЗАХ налчгар юмны налчис налчис хөдлөх.

НАЛЬХ 1. нүдний дотоод булангийн хөлх мах; *нальх нь улайх; нальх нь хөөх;* 2. **зарим** хүнсний зүйлийн гадуур бүгнэгдэж гутсанаас болж тогтсон нялгар зүйл; *махны нальх.*

НАЛЬХРАХ нальх бий болох; *мах нальхрах.*

НАЛЬХРУУЛАХ нальхрахын үйлдүүлэх хэв.

НАЛЬХТАХ нальх бий болон тогтох; *мах нальхтах.*

НАЛЬШИМ у р г а м а л 1. халуун оронд асаж ургадаг бутархаг ургамал; 2. мөнхүү ургамлын үр, үр нь анхилам үнэртэй бөгөөд халуун чанартай.

НАМ I нийгмийн нэгэн ангийн жолоодох хэсэг нь бөгөөд түүний ашиг тусыг хамгаалж, нөгөө эсрэг ангитай явуулах тэмцлий **нь удирдах** улс төрийн байгууллага; **нам засаг** х о р ш.; *Монгол Ардын Хувьсгалт Нам; Зөвлөлт Холбоот Улсын Эвхамт нам; нийгэм журамт нам; ажилчны нам; хөдөлмөрийн нам; коммунист ба ажилчны намуудын зөвлөлгөөн; намын удирдлага;* **намын үүр** (намын анхан шатны байгууллага); **намын төв хороо** (намын удирдах дээд байгууллага); **намын дүрэм** (намын гишүүд, намын байгууллагуудын дагаж мөрдөх заавар); **намын батлах** (намын гишүүн мөн болохыг илэрхийлсэн бичиг); **намд орох** (намд элсэх): **намд элсэх** (намын дүрэм программыг зөвшөөрч намын гишүүн болох); **намын орлогч** (намын жинхэнэ гишүүн биш бөгөөд тогтоосон хугацаанд таслах эрх үл эдлэх гишүүд); *нараа дагавал даарахгүй, намаа дагавал гэнэдэхгүй* з ү й р.

НАМ II сана зорилго нэгтэй бүлэг хэсэг; *хулгайн нам; дээрэмчний нам; нам нийлэх сэм хуйвалдах;* 2. адгуус, ургамлын аймаг, төрөл бүлэг; *сонгинын нам; мийн нам.*

НАМ III өндөртэй эсэргүүцэлдсэн утга, өндрөөшөө богино, *нам сандал; нам болгох; нуруугаар нам; чамаас нам юм; нам дор газар.*

НАМ IV чимээ аниргүй, сэм; нам жим; **нам гүм**; *шөнийн арван хоёр цагийн үед нам гүм болов;* **нам цохих** (чимээгүй болтол цохих); **нам дарах** (нуун далдлах).

НАМАА I архи хийх сав; *намаа дүүрэн архитай наргиж даргиж явтал... .*

НАМАА II: **хамаа намаа, хамаа намбаа** хамаа намаагаа алдах, хээгээ алдах.

НАМАА III: **навч намаа** навч нахиа; *модны навч намаа.*

НАМАГ 1. зүлэг шавартай нойтон газар; *намагтай газар; намагт шигдэх;* 2. ш и л ж сэн лавшран орох; *хүнд суртлын намагт шигдэн орсон байна.*

НАМАГДАХ дэндүү намагтай учир тохиромжгүй болох.

НАМАГДУУ намаг ихээхэнтэй.

НАМАГРАХАГ намаг ихтэй.

НАМАГРАХУУ намаграхаг.

НАМАГТАХ намагтай болох, намаг тогтох.

НАМАЙХ I зөөлөн дөлгөөн, алгуур, тайван байх, налайх; *хаврын намайсан сайхан өдөр; мал намайтал билчээрлэж байна.*

НАМАЙХ II хотойх; *шал намайж орхижээ.*

НАМАЛЗАХ 1. хотолзон, хонхолзон доош дээш болж хөдлөх; *онгоцны гишгүүр намалзаж хөдлөв;* 2. зөөлөн эелдэг хөдлөх; явах; **нахилзах намалзах** х о р ш..

НАМАЛЗУУЛАХ намалзахын үйлдүүлэх хэв.

НАМАНЧЛАЛ 1. шашны ёсны гэм унаалаа арилгах тухай даатгал залбирал; 2. гэм буруугаа гэмшин санаж гуйх; *алга хавсран наманчлал гуйж суув;* **наманчлал тавих** (наманчлах санаа агуулах).

НАМАНЧЛАХ 1. гөмшин гуйх, **гэмшин** сан**ах**; *нүглээ наманчлах; гэмээ наманчлах;* 2. гар хамтатган залбирах; гараа **наманчлах.**

НАМАНЧЛУУЛАХ 1. **наманчлахын** үйлдүүлэх хэв; 2. юмны дээд талыг мөргүүлэн, доод талыг алцайлган босгож тавих; *банз модыг наманчлуулан өрж хатаах.*

НАМАР 1. зуны дараахь улирал 7, 8, 9-р гурван сар; *намар болох;* 2. зурхайн ёсоор жилийг зургаа хуваахад дөрөвдүгээр хувиар; намрын өдөр шөнө тэнцэхийн урьд хожид нэжгээд сар; **намрын хонгор салхи** (намрын урьхан зөөлөн салхи); **намрын хугас дунд** (сарны зурхайн жилийн хорин дөрвөн улирлын нэг, намрын өдөр шөнө тэнцэтгэл); **намрын уур орох** (сарны зурхайн жилийн хорин дөрвөн улирлын нэг, зуны сүүл сард намрын байдал орох үе); **намрын шар нар** (намрын илчит нар); **халуун намраар** (намар эрт); *намар тосоо гүзээлбэл, хавар тугалаа гүзээлнэ* зүйр **намрын сиймхийлэг цэцэг** ургамал (өвсөн ишнээс ургадаг, улаан өнгөтэй, хэлтэс нь ацтай, намар цэцэглэдэг нэгэн зүйл цэцэг); **намрын хайтан цэцэг** ургамал (өвсөн ишнээс ургана, ногоон навчтай, цайвар улаавтар цэцэг); **намрын мандарваа цэцэг** ургамал (өвсөн иштэй, газраар бүрхэж ургана, цэцэг нь хүрэн бөгөөд удвал цэцгийн адил, туурцаг шар, навч нь мандарваа цэцгийн навчнаас арай багахан нэгэн зүйл цэцэг).

НАМАРГА ургамлын навч шилмүүс дээр тогтсон шүүдэр ус.

НАМАРЖАА (Н) намрын цагт нутаглах нутаг бууц; *айлууд намаржаанаасаа нүүгээгүй байна; намаржаанд буух.*

НАМАРЖААЛАХ намаржаандаа буудаллах.

НАМАРЖААЛУУЛАХ намаржаалахын үйлдүүлэх хэв.

НАМАРЖИН намрын турш; *намаржин өвлийн бэлтгэл хийсэн бригад байгаа юм.*

НАМАРЖИХ намрыг өнгөрөөх; *тавтай сайхан намаржиж байна уу?*

НАМАРЖУУЛАХ намаржихын үйлдүүлэх хэв.

НАМАРШИХ цаг улирлын байдал намрын шинжтэй болох; *намаршиж өвс гандав.*

НАМАРШУУЛАХ намаршихын үйлдүүлэх хэв.

НАМБА 1. төлөв байдлаар түвшин аятай; *тэр гуай намбатай сайхан хүн шүү; намбатай харагдаж байв;* 2. гадаад байдал төв үзэмжтэй; *намбатай алхаж явна; намбы нь таарууллж хувцасласан байна.*

НАМБААГҮЙ эмх замбараагүй, эх толгойгүй.

НАМБААНАЦАГ элдэв зүйлийн юм.

НАМБАГАНАХ намбагар юмны намбага намбага хөдлөх аашлах; 2. гангалах, хээнцэрлэх.

НАМБАГАР 1. дөлгөөн, номхон даруу байдалтай; 2. шоодсон гангалж хээнцэрлэх зан байдал гаргамтгай; *торгон дээл өмсөөд урт ханцуй унжуулсан намбагар хүн явж байв.*

НАМБАГҮЙ төлөв зэхий, овлигогүй; *настай хүн атлаа яасан намбагүй хүн бэ?*

НАМБАЙЛГАХ намбайхын үйлдүүлэх хэв, намбагар болгох.

НАМБАЙХ намбагар байдал гаргах.

НАМБАЛЗАХ намбагар юмны намбас намбас хөдлөх, аашлах.

НАМГАНАХ юмны намга намга хийж хөдлөх.

НАМДААХ намдахын үйлдүүлэх хэв, намдахад хүрүүлэх; *шүүгиан намдаах.*

НАМДАХ I 1. нам болох, намхан болох; 2. намын учир тохиромжгүй болох.

НАМДАХ II намжих, буурах, дарагдах, зогсох; *өвчин нь намдах; шуурга намдахаар хөдлөв.*

НАМДУУ арай нам, баахан нам.

НАМДУУЛАХ намдахын үйлдүүлэх хэв.

НАМЖААХ намжуулах.

НАМЖИР I ихэмсэг зан авир, байдал; *намжиртай дуугарах; намжиртай харах.*

НАМЖИР II буддын шашны ёсны гэлэн хүний орхимж мэт нөмрөх нэгэн зүйл давхац хувцас.

НАМЖИРДАХ ихэмсэг сүр үзүүлсэн зан авир гаргах; нүд ширэвхийлгэн зангах; *намжиртай үг хэлэх; дарга маань их л намжирдаж байв.*

НАМЖИРДУУ намжирдах байдалтай.

НАМЖИРДУУЛАХ намжирдахын үйлдүүлэх хэв.

НАМЖИРДУУХАН баахан намжирдуу.

НАМЖИРДУУШИГ намжирдах шинжтэй.

НАМЖИРТАЙ 1. намжир ихтэй; *тэр чинь намжиртай хүн шүү;* 2. маяг янз ихтэй.

НАМЖИХ 1. нам гүм болох, намжуу болох; *их дуу чимээ намжив;* 2. буурах, дарагдах; *халуун намжмагц хөсөг хөдлөв; өвчин нь намжиж байна;* 3. арилах, хүч нь саарах; *бороо намжив; шуурга намжихад гадаа гарч харав.*

НАМЖУУ зөөлөн, даруу, бага, гайгүй; *энэ өдөр салхи намжуу байна; халуун нь намжуу байв; хэл ам намжуу; хэрүүл шуугиан намжуу.*

НАМЖУУЛАХ намжихын үйлдүүлэх хэв, намжихад хүргүүлэх.

НАМИА хуягийн мөрөвчний хойт жигүүрийн ойр хадсан гурван хэсэг төмөр.

НАМИЛЗАХ 1. намиран хөдлөх, нахилзан хөдлөх; *соёл эрдэнийн соёмбо үсэг солонгол-сон, сүрт улаан туг намилзан мандана* (дуу); 2. зөөлрөх, уян зөөлөн болох; *намилзсан сайхан элдүүртэй нэхий; намилзтал дэвтсэн ааруул.*

НАМИЛЗГАНА наймалзаргана.

НАМИЛЗГАНАТАХ намилзгана бий болох.

НАМИЛЗУУЛАХ намилзахын үйлдүүлэх хэв.

НАМИЛХАЙ ууцны хоёр хажуугийн нимгэн хэсэг.

НАМИНЧЛАХ наманчлах.

НАМИРАА 1. навч шилмүүсэн дээр тогтсон ус; *намираа тогтох;* 2. намирч байгаа нь; *намираа хур;* **намираа бороо** (зөөлөн бороо).

НАМИРАХ уян хатан буюу ширхэгтэй юм үл мэдэг хөдлөн байх; *ус намиран үнжих; салхинд туг намиран хийсэх; бороо намиран орох.*

НАМИРУУЛАХ намирахын үйлдүүлэх хэв.

НАМНАЛ намнах үйлийн нэр.

НАМНАЛГА намнал.

НАМНАХ 1. морин дээрээс харвах, **хөөх;** *бөмбөг намнах; ан гөрөөс намнаж явжээ;* **намнах харвах** хорш.: 2. алахын цээрлэл; *зээрэн дээлтэй дүүгээ жэрэв хараад намначихав* (дуу).

НАМНУУЛАХ намнахын үйлдүүлэх хэв.

НАМС I: намс намс хийх намалзах, хотолзох, навталзах; *нимгэн банзан шал намс намс хийж байв.*

НАМС II: намс яр нүүрийн орчин гардаг, шар ус цувран, дуссан газар хагажтах яр).

НАМСАХ 1. улмаар нам болох; 2. намдах; 3. намжих; *дуу нь намсаж дүр нь зөөлөн болов.*

НАМСГАХ намсахын үйлдүүлэх хэв, нам болгох.

НАМСХИЙХ 1. хотосхийх, навтасхийх; *намсхийн бөхийв;* 2. түр намжих.

НАМТААХ намтахын үйлдүүлэх хэв, намтгах; *өвчин намтаах эм өгнө үү?.*

НАМТАР 1. *аливаа юмны амьдрал ахуйг тоочин бичсэн түүх;* **түүх намтар** хорш.; *өөрийн намтар* 2. хуучирсан аливаа зохиол тууж; *саран хөхөөний намтар;* **намтраа дуудуулах** (муу ажил үйл хийж явсны нь сөхөж тоочих).

НАМТАХ улмаар нам болох.

НАМТГАХ нам болгох.

НАМУЙХ 1. хотойх, хонхойх; 2. намуун аятай болох.

НАМУУ зөөлөн, дөлгөөн, даруу, эетэй, намжуу; *намуу зантай; салхи намуу байна;* **намуу цэцэг** ургамал (ихэнхдээ том улаан цэцэгтэй байдаг нэг зүйл өвсөрхөг ургамал).

НАМУУН 1. тогтнуун, зөөлөн; *намуун салхи;* 2. шилжсэн даруу, төлөв, дөлгөөн, тогтнуун; *намуун зантай хүн.*

НАМУУХАН зөөлөн, зөөлхөн; *намуухан дуугаар хэлэв; намуухан яваарай.*

НАМХАЛЗАХ 1. навхалзах; 2. намганах.

НАМХАН баахан нам; *намхан нуруутай; намхан таазтай байшин.*

НАМХАНДАХ хэтэрхий намхан болох.

НАМХАНДУУ арай намхан, нилээд намхан.

НАМХРАХ намжих, буурах, дарагдах; *усны үер жаал намхарчээ; хөл намхрав; чимээ намхарчээ.*

НАМХРУУЛАХ намхрахын үйлдүүлэх хэв.

НАМХТАХ улмаар намхан болох.

НАМХТГАХ намхан болгох.

НАНДИГНАХ нандин болгож үзэх; *над нандигнаж явдаг зүйл бол намын батлах мөн.*

НАНДИГНУУЛАХ нандигнахын үйлдүүлэх хэв.

НАНДИН ховор эрхэм юм; **нандин жиндин** х о р ш.; *гишүүн хүнд батлахнаас өөр нандин юм байдаггүй.*

НАНЖИН ганган, хээнцэр, цэмцгэр; **нанжин чавга** (нэг зүйл чавга).

НАНЧИГДАХ нанчихын үйлдэгдэх хэв, нанчуулах.

НАНЧИЛДАХ жанчилдах, зодолдох, цохилдох.

НАНЧИЛДУУЛАХ нанчилдахын үйлдүүлэх хэв, зодолдуулах.

НАНЧИЛЦАХ нанчихын үйлдэлцэх хэв.

НАНЧИЛЦУУЛАХ нанчилцахын үйлдэлцэх хэв.

НАНЧИХ жанчих, зодох, цохих.

НАНЧУУЛАХ 1. нанчихын үйлдүүлэх хэв; 2. нанчигдах, зодуулах.

НАНШАА 1. үглээ, яншаа; 2. мангуу, дүйнгэ.

НАНШААХ 1. мангуу хүний дуншин хэлэлцэх; 2. үглэх, янших.

НАНШААЧ 1. дуншдаг хүн, дуншаач; 2. яншаа, дуншаа, үглээ зантай хүн.

НАНШИН: наншин нуншин гунших байдал.

НАНШИХ 1. донших, моншрох; 2. янших, үглэх; 3. нанчих, жанчих, зодох, цохих.

НАНШУУЛАХ наншихын үйлдүүлэх хэв.

НАР (АН) I дэлхий ба бусад гаргуудын тойрон эргэх огторгуйн гэрэл сацрах од; **нар ургах** (өглөө болж нар ил гарах); **нар гарах** (а. нар дээш мандан үзэгдэх; б. баяртай явдал тохиолдох; *миний нар гарав*); **нар мандах** (нар гарч, нилээд дээш дэгжих); **нар дэгжих** (нар мандах); **нар хүүшлэх** (нар халхлагдах); **нар шингэх, нар жаргах, нар орох** (нар баруунаа бууж орой болж үзэгдэхгүй болох); **нар хирлэх** (нар хиртэх): **нар хиртэх** (нарны явах замд сар ташаалан ойртож халхлагдах); **нар барих** (нар хиртэх): **нар таших** (нар үлэмжхэн хэлбийх); **нар хүрээлэх** (нарыг тойрон дугарigласан солонго татах); **нар хошлох** (нарны хажууд солонго мэт сацрал гарах); **нар буцах** (өвөл зуны туйл болох, өвлийн туйл нь аргын улирлын арван хоёрдугаар сарын хорин хорин таван хоёрын хооронд тохиолдоно, үүнээс өдөр уртдан үүснэ; зуны туйл нь аргын улирлын зургадугаар сарын хорин хорин таван хоёрын хооронд тохиолдоно, үүнээс өдөр богинотон үүснэ); **шар нар бор хоног** (өдөр шөнө); **шар нар бор хоног өнгөрүүлэх** (хэвийн биш байдлаар өдөр шөнийг нөгцөөх); **нар уд болох** (өдөр дүл болох); **наран угаал** (наранд шарж эмчлэх эмчилгээ); **хурц нар** (цоносон, төөнөсөн халуун нар); **наранд шарах, наранд ээх** (биеэ нар дагуулан халаах); **наранд харвагдах, наранд цохигдох** (нарны илчид хэтэрхий шарагдсанаас болж өвчлөх); **наранд гаргах** (юмыг наранд үзүүлэх); **нар сацрах** (нарны гэрэл туяа сацрах); **нар дагах** (нарны гэрэл дагах); **нар салхи үзээгүй** (а. нар салхинд огт явдаггүй буюу явахыг хичээдэггүй, дурладаггүй; б. ажил үйл хийдэггүй биеэ атарлаж сурсан); **нар салхи үзэхгүй** (нар салхинд явж чадахгүйд хүрсэн); **нар салхины бараа хараагүй** (биеэ хэтэрхий атарлаж заншсан); **нар салхины бараа харахгүй** (нар салхинд явж чадахаа больсон); **нар зөв** (баруунаа); **нар буруу** (зүүнээ); **нарны аймгийн ертөнц** (Ангараг, Буд, Бархасвадь, Сугар, Саньчир, Тэнгэрийн ван, Далайн ван, Дэлхийн ван); **нарны халх** (нар халхлах шүхэр); **сар нар болсон гэр** (уранхай ноорхой гэр); **нарны хэмнүүр** (нарны явдлыг хэмнэх хэрэгсэл); **наран ноогоо** у р г а м а л (хээр ургана, цагаан үндэстэй, улаан иштэй, ногоон навчтай, шар цэцэгтэй, хар үртэй, үрийг борлуулж иднэ); **наран цэцэг** у р г а м а л (том шар цэцэг бүхий өндөр ургадаг ургамал, үрий нь авч тос боловсруулна); **нартай цэцэг** у р г а м а л (модорхог иштэй, салаа навч нягт, ялма модтой адил, цэцэг нь улаан цагаан шар гурван зүйл байдаг); **наран удвал цэцэг** у р г а м а л (усанд ургадаг, дэгдүүр навчтай, зангууны цэцгээс томоохон цэцэгтэй, шар цагаан хоёр зүйл бий, нар зүг хандаж цэцэглэнэ, нар шингэхэд навчны дор нууна); **наран хайнаг** а м ь т а н (монголын бух сарлагийн үнээ хоёрын хоорондоос гарсан хайнаг, усан хайнаг ч

гэж зарим газар хэлдэг); **наран тэмээ а м ь т а н** (Африк, Ази тивийн зарим газар орших нэг бөхтэй тэмээ, үс ноос бага боловч сүү сайтай, говь цөл газар аян жин тээхэд хэрэглэнэ); **нар нар наашаа, сүүдэр сүүдэр цаашаа** (нар хүсч хүүхдүүд зэрэг зэргээр өгүүлэх үг); **нар эрт, нас залуу з ү й р;** (юм юм эрт гэсэн утга);

НАР II 1. олон тооны дагавар, саланги бичнэ, хүн төрөлхтнөөс бусад адгуус ан амьтан ургамал, амигүй зүйлд үл хэрэглэнэ; *багш нар; дүү нар; дарга нар; сайд нарын зөвлөл;* 2. хүний нэрийн дараа бичвэл хэд хэдэн, олон гэсэн утгатай болно; *Сүхбаатар нар шөнө дүл явсаар нэг тосгонд хүрэв; Дорж, Дагва, Балдан нар ирэв;* 3. тэнгэр, бурхан гэсэн үгийн дараа бичиж, түүний олныг заана; *тэнгэр бурхан нар.*

НАРАМГАНАХ наримгар юмны үргэлжлэн хөдлөх.

НАРАМГАР наримгар; *нарамгар хамартай.*

НАРГИА наргиан, үймээнтэй, хөгжөөнтэй; *наргиа хүн;* **наргиа даргиа** х о р ш..]

НАРГИАН 1. цэнгэл, найр; *наргиан хийх; найр наргианд дуртай;* 2. я р и а хачин жигтэй байдал; *наргиантай юм болох нь шив!*

НАРГИАЧ найр наргианд дуртай, хөгжөөнтэй.

НАРГИЛ: наргил мод у р г а м а л халуун оронд ургадаг өд мэт навчтай өндөр мод; *наргил модны самар; наргил модны тос.*

НАРГИХ 1. цэнгэл, зугаа хийх; *дуу хуа болон наргиж байв;* 2. ичгүүртэй явдал тохиолдож хөглөх; *чи чинь яаж наргиж явна аа!*

НАРДАХ наранд хэтэрхий шарагдаж хордох; *манай хүүхэд нардсан юм үү, бөөлжөөд л байна.*

НАРДУУЛАХ нардахын үйлдүүлэх хэв.

НАРИВЧЛАХ нарийвчлах, нягталж хянах; *наривчлан шалгах; наривчлан тодорхойлох.*

НАРИЙВТАР арай нарийн.

НАРИЙВЧЛАГДАХ нарийвчлахын үйлдэгдэх хэв.

НАРИЙВЧЛАЛ нарийн нягт үзэх нь; *нарийвчлалгүй болохгүй хэрэг.*

НАРИЙВЧЛАХ нягтлах, нарийн тодорхой хянах, шалгах; *нарийвчлан хянах; нарийвчлан судлах.*

НАРИЙВЧЛУУЛАХ 1. нарийвчлахын үйлдүүлэх хэв; 2. нарийвчлагдах.

НАРИЙДАХ хэтэрхий нарийн болох, нарийны учир тохиромжгүйдэх.

НАРИЙДУУЛАХ нарийдахын үйлдүүлэх хэв, хэтэрхий нарийн болгох.

НАРИЙЛАХ 1. юманд болгоомжтой хянамгай хандах, хичээнгүйлэх; *хэргийг нарийлан шалгах; нарийлан ажилладаг хүн;* 2. нууцалж үл задруулах; *үзэж мэдсэнээ нарийлах;* 3. харамлаж хайрлах, хурхаглах; *эд юмаа нарийлах;* 4. нарийн нунтаг юмыг дахин нарийн болгох, шигших; *эм нарийлах;* **нарийлах аяга** (юм галхлах сав).

НАРИЙН 1. бүдүүн гэсэнтэй эсэргүүцэлдсэн утга; бүдүүн биш; *нарийн шугам; нарийн гуурс; нарийн гурил; нарийн шаазан; нарийн хурган дотортой дээл;* **нарийн гэдэс** (гэдэсний нарийн хэсэг); **нарийн шүрэг** (ногоо хярах зэвсэг); **нарийн дуу** (шингэн дуу); 2. өргөн гэдэгтэй эсэргүүцэлдсэн утга; өргөн биш; *нарийн зам; нарийн банз; нарийн энтэй бөс;* 3. ш и л ж с э н уран, ур сайтай, хэцүү, төвөгтэй; *нарийн хийцтэй тоног; нарийн зураг хөрөг; нарийн сийлбэр;* 4. нандин, гоёмсог, тамсаг; **нарийн нандин, нарийн ширийн** х о р ш.; **нарийн бараа** (торго торгомсог); **нарийн эд** (сайн эд); **нарийн чулуу** (өнгөлж гилгэр болгож болох чулуу); 5. хянамгай, болгоомжтой; **нарийн хэрэг** (а. нууц хэрэг: б. нягталбал зохих хэрэг); **нарийн арга** (уран арга); **нарийн судлах** (нягтлан үзэх); **нарийн тодорхой** (тов тодорхой); **нарийн нанжин** (хянамгай); 6. я р и а харам, харамч, эд юмдаа харуу, өглөгч биш; *нарийн хүн;* **нарийн зан** (харамч); ☆ **нарийн хувь** (цагийн хэм, секунд); **нарийн хоол** (шанз болон ногоо, үр жимс зэргийг найруулан төвөг гаргаж амтлан хийсэн хоол); **нарийн бичгийн дарга** (а. аливаа нууц бичиг хэрэг, хурлын товч явц зэргийг хөтлөгч ажилтан; *хурлын нарийн бичгийн дарга;* б. аливаа албан байгууллагад сонгогдсон удирдагч; *төв хорооны нарийн бичгийн дарга; ерөнхий нарийн бичгийн дарга;* в. зарим газрын хариуцлагатан; *эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга);* **нарийн боов** (амтлаг боов жимсний зүйл); **нарийн өвчин** (улаан хоолой, ходоод гэдэсний өмөн өвчин).

НАРИЙНДАХ хэтэрхий нарийны учир тохиромжгүй болох, нарийдах.

НАРИЙНДУУЛАХ нарийндахын үйлдүүлэх хэв, нарийдуулах.

НАРИЙНТАХ нарийн өвчин тусах.

НАРИЙНТУУЛАХ нарийнтахын үйлдүүлэх хэв.

НАРИЙСАХ нарийн болох.

НАРИЙСГАХ нарийн болгох.

НАРИЙСГУУЛАХ нарийсгахын үйлдүүлэх хэв, нарийн болгуулах.

НАРИЙТАХ улам нарийн болох.

НАРИЙТГАХ нарийтахын үйлдүүлэх хэв, улам нарийн болгох.

НАРИЙТГУУЛАХ нарийтгахын үйлдүүлэх хэв, улам нарийн болгуулах.

НАРИЙХАН арай нарийн, баахан нарийн.

НАРИЛАХ нарийлах.

НАРИМГАНАХ нарамганах, , нармалзах нармилзах.

НАРИМГАР нарамгар, навшгар; *наримгар хамар; наримгар хуу.*

НАРИН нарийн.

НАРЛАХ нар дагаж ээж шарж суух, наранд гарах.

НАРЛУУЛАХ нарлахын үйлдүүлэх хэв, наранд гаргах; *хүүхдээ нарлуулж байна.*

НАРМАЙ I хөвчин их; *нармай улс.*

НАРМАЙ II ханшаарын дотоод тал.

НАРМАЙЛГАХ нармайхын үйлдүүлэх хэв.

НАРМАЙХ нарамгар болох.

НАРМАЛЗАХ нармилзах.

НАРМАЛЗУУЛАХ нармалзахын үйлдүүлэх хэв.

НАРМИГАР нарамгар, навшгар.

НАРМИЙЛГАХ 1. нармийхын үйлдүүлэх хэв, нармигар болгох; 2. юмыг сүйтгэж эвдлэн хэрэгцээгүй болгох.

НАРМИЙХ 1. нармигар болох; *нармийсан хамартай;* 2. юм эвдрэх хэмхрэх, хэрэгцээпээс гарах.

НАРМИЛЗАХ нармалзах, наримганах.

НАРМИЛЗУУЛАХ нармилзахын үйлдүүлэх хэв.

НАРС (АН) ургамал бөөрөнхий боргоцойтой, мөнх ногоон урт шилмүүстэй нэгэн зүйл мод; *нарсан ширээ; нарсан банз; нарсан ой; нарсны давирхай; нарсны шилмүүсний шүүс; нарсны боргоцой.*

НАРСАН ургамал майлсны мэт иштэй, нарсны шилмүүсэнд адил шилмүүстэй, нилээд өндөр нэг зүйл мод, маш хүчтэй эхүүн амттай үртэй, хяруу унасан үрийг идэж болно; **нарсан өвс** ургамал (хээр ургана, шувуун нударгатай адил нэгэн зүйл ногоо).

НАРТАЙ нар бүхий, цэлмэг; *нартай өдөр; нартай бороо орох; би дээр нартай байхад ирсэн; нартай унтах.*

НАРЦАХ арцах, маргах.

НАРШИХ 1. юмны чанар нарны гэрэлд шарагдаж муудах; 2. наранд шарагдсанаас болж өвчин олох; *хүүхэд наршчих бий, болгоомжил! унага наршиих.*

НАРШУУЛАХ наршихын үйлдүүлэх хэв.

НАРЬ мах.

НАРЬДАХ нарийдах.

НАРЬДУУЛАХ нарьдахын үйлдүүлэх хэв, нарийдуулах.

НАС (АН) 1. хүн, адгуус, ургамлын хөгжил, өсөлтийн үе, шат; *залуу нас; урт настай, удаан жаргалтай* (ерөөл); *нас өндөр болох;* **настай хүн** (нас ахисан, хөгшин); *насны хувирал; насны ялгавар; насны тоогоор; насны эцэс болох;* 2. хүн амьтан ургамлын амьдран ахуй жил; *нэг настай, нялх үстэйгээс нь эхлэн.. наян настай хөгшин, найман настай балчир; олон наст ургамал; насны зөрөө;* **нас гүйцэх** (хонь үхэр зэрэг малын зургаан шүд нь гарч жигдрэх; *нас гүйцсэн хонь; нас гүйцсэн шар);* **насанд хүрэх** (хүний арван найман нас хүрэх); **насаа идэх** (насандаа тэнцүүргүй жижиг биетэй); **насан турхруу** (бүх насаараа); **насаараа, насан туршид** (бүх насны турш); **нас ахих** (хөгшрөх); **нас болох** (а. их л хөгшрөх: б. үхэх); **нас дарах** (хөгширсөн байдал орох; *эрийг нас дарах, эргийг ус дарах);* **насаа дарах** (насаа бага болгох); **их нас** (а. өтөлсөн нас; *их нас наслав, одоо үхэхэд гомдолгүй;* б. соёолонгоос дээш насны морь; *их насны морь уралдах);* **нас хэтрэх** (хууль ёсоор ажил хөдөлмөр хийвэл зохих наснаас илүү наслах); **нас тэнцэх** (хууль ёсоор ажил хөдөлмөр хийвэл зохих нас тохирох); **насанд хүрээгүй** (арван найман нас хүрээгүй буюу хуулийн бүрэн эрхийг эдлэх насанд хүрэх болоогүй); **нас нөгчих, нас барах, нас эцэслэх** (үхэх); **талаар насаа барахгүй** (хэрэг тустай ажил хөдөлмөр хийхгүйгээр бүх насаа үрж болохгүй; *тамтаггүй үйл үйлдэж талаар насаа ба-*

рахгүйг хүн бүхэн хичээх хэрэгтэй!); **сургуулийн өмнөх насны хүүхэд** (3—7 хүртлэх насны хүүхэд); **сургуулийн нас** (8—18 хүртлэх нас); **нас чинь залуу, цус чинь шингэн байна** (ирээдүй бий); *хайран биеийг нас дарж, хан уулыг цас дарах* з ү й р.

НАСГҮЙ: **насгүй болох** бие нь хэтэрхий муудаж, удаан амьдарч чадах нөхцөлгүй болох; *тэр гуай ч насгүй болсон хүн шив дээ.*

НАСАД хэзээд, үргэлжид, насан туршид; *насад баясна; насад гомдоно; насад зүтгэнэ; насад цээрлэнэ.*

НАСЖИХ хөгшрөх, настай болох, их наслах.

НАСЖУУ насжсан байдалтай; *тэр гуай чинь аргагүй л насжуу харагдаж байна.*

НАСЖУУЛАХ насжихын үйлдүүлэх хэв.

НАСЛАХ удаан хугацаанд амьдрах; *урт насалж удаан жаргах болтугай!*

НАСОС шингэн зүйл болон хийн бодис хөөрөгдөн гаргах машин; *хийн насос.*

НАСТАЙ нас ихтэй, нас бүхий; *настай болох; арван найман настай; хэдэн настай вэ? настай хүн.*

НАСТАЙВТАР арай настай; *настайвтар хар хүн манайд ирэв.*

НАСТАЙХАН нилээд настай; *настайхан хүн харагдсан шүү.*

НАСТАН 1. хөгшид настайчууд; *тавин настан; өндөр настан; ная хүрсэн настнууд найран дундаа найгаж байна;* 2. үе тэнгийн олон хүмүүс; *арван найман настан; гучин настан.*

НАТАЙХ юмны дээрээс харахад доош тодорхойгүй халхлагдах.

НАТГАМТГАЙ натгамхай.

НАТГАМХАЙ бусгамхай.

НАТГАХ зайлсхийх.

НАТРИЙ хөнгөн, зөөлөн, цагаан өнгөтэй шүлтэт төмөрлөг буюу химийн нэгэн язгуур махбод.

НАТУРАЛИЗМ урлаг утга зохиол дахь буржуйлиг хөрөнгөтний чиглэл, энэ чиглэл бол реализмын эсрэг бөгөөд байгалийн хуулийг нийгмийн хуультай адилтгаж, агуулгыг үл харгалзан зөвхөн гадаад хэлбэрийн мөн чанарыг анхааран үзнэ.

НАХАЙ доод урүүлын дорхи хонхор.

НАХИА ургамлын навчлан **завдаж урган** цухуйсан нь; **навч нахиа** х о р ш..

НАХИАЛАХ нахиа нь ургах; *хавар мод ургамал нахиалан, жигүүртэн шувуу жиргэхэд...*

НАХИАЛУУЛАХ **нахиалахын үйлдүүлэх** хэв.

НАХИАТАХ нахиалах, нахиа ургах.

НАХИГАНАХ уян нарийн юмны нахиа нахиг хөдлөх.

НАХИГАР бөхгөр, махигар, тахир; *нахигар уурга; нахигар саваа.*

НАХИД уулын хярын бяцхан хотгор нахиу.

НАХИДАГ нахид; *тэр нахидгаар даваад ормогц... .*

НАХИЙЛГАХ нахийхын үйлдүүлэх хэв, *гулзайлгах.*

НАХИЙХ нахигар болох, гулзайх.

НАХИЛАХ ургамлын үзэмжтэй **сайхан** ургах; **найгах нахилах** х о р ш..

НАХИЛЗАХ 1. уян нарийн юмны **нахис** нахис хөдлөх; *модны мөчир нахилзан хөдлөх;* 2. бөхөлзөх: **нахилзах бөхөлзөх** х о р ш..

НАХИЛЗУУЛАХ нахилзахын үйлдүүлэх хэв.

НАХИСХИЙЛГЭХ нахисхийхийн үйлдүүлэх хэв.

НАХИСХИЙХ бөхөсхийх, **тахисхийх;** *бөхөс нахисхийх.*

НАХИУ 1. хэвийн байдлаас намхан хотгор; *нахиу хамар;* 2. уулын хярын хотгор, сэтэрхий газар, нахидаг ч гэдэг; *уулын нахиу.*

НАХИХ яламгалзан ойртож шадарлахыг хичээх; **наалдаж нахих** х о р ш..

НАЦИОНАЛИЗМ үндэсний үзэл.

НАЦИОНАЛИСТ үндэсний үзэлтэн.

НАЧИН 1. а м ь т а н халин нисэгч **махчин** шувуу; **начин шонхор** х о р ш.; 2. бөхийн цол; **улсын начин** (улсын наадамд тав давагчдын цол).

НАЯ (Н) тооны нэр, найман арав; *наян хургатай хонь; наян жилийн найр хийж, жа-*

ран жилийн жаргал хийж, амар сайхандаа жаргаж гэнэ (үлгэрийн төгсгөл); ☆ **наян найраг** (хүний биед байх дүр хэлбэр үзэстэлэнтэй өнгө сайхан, байдал эелдэг мэтийн сайхан ялгамжаа).

НАЯАД 1. ная орчим; 2. тус бүр ная.

НАЯД тооны нэр, арван асанги, арван хоёр оронтой тоо; **их наяд** (тооны нэр, арван наяд, арван гурван оронтой тоо).

НАЯДУГААР дэс тооны наяд гохиолдсон нь; *наядугаар суудал; наядугаар зүйл; наядугаар боть.*

НАЯУЛ (АН) хамт ная; *бүгд наяул явж гэнэ.*

НАЯХАН дөнгөж ная; *над наяхан мөнгө байна.*

НЕГАТИВ гэрэлд эмзэг чанартай хальсанд гэрэлтэй газар нь хар, сүүдэртэй газар нь цагаан гарсан дүрс.

НЕЙТРОН атомын цөмд ордог цахилгаан цэнэггээ алдсан материаллаг хэсэг.

НЕТТО аливаа барааны хайрцаг шуудай боодол зэргийг хэмжээнд үл оруулсан цэвэр жин.

НЕФТЬ түлш болгож хэрэглэх ба мөн керосин, бензин мэтийн элдэв зүйлийг гарган авах түүхий эд болох тосорхог шингэн эрдсэн шатах бодис; *нефтийн аж үйлдвэр; нефть ундрал.*

НИВШИХ жанчих, гүвших.

НИВШРЭХ I 1. бие хүндрэх, залхуу хүрэх; *тэнгэр аягүйцэхэд бие нившрэх; өнөөдөр ясан нивширсэн өдөр вэ!* 2. хүнд хэцүү болох; **нивширтэл ачих** (дааж ядтал ачих); **нивширтэл унтах** (хэтэрхий унтах); **нивширтэл жанчих** (хүндэд жанчих).

НИВШРЭХ II багшрах; *нивширсэн олон хонь билчиж явна.*

НИГУРС нугас II.

НИГҮРС суман мод.

НИГҮҮЛСҮҮЛЭХ 1. нигүүлсэхийн үйлдүүлэх хэв; 2. нигүүлсэгдэх.

НИГҮҮЛСЭГДЭХ нигүүлсэхийн үйлдэгдэх хэв.

НИГҮҮЛСЭЛ нигүүлсэх үйлийн нэр; **нигүүлсэл өршөөл, энэрэл нигүүлсэл** х о р ш..

НИГҮҮЛСЭЛГҮЙ энэрэл өршөөлгүй, өрөвдөх сэтгэлгүй, нинжин сэтгэл байхгүй.

НИГҮҮЛСЭЛТЭЙ 1. нигүүлсвэл зохих зүйл бий; *нигүүлсэлтэй болсон амьтан;* 2. нигүүлсэхүй, өршөөгүй, энэрэнгүй сэтгэлтэй, өрөвдөх сэтгэлтэй, нинжин сэтгэлтэй.

НИГҮҮЛСЭНГҮЙ нигүүлсэх сэтгэлтэй, энэрэнгүй нинжийн сэтгэлтэй, нигүүлсэх зан чанар; *нигүүлсэнгүй хүн.*

НИГҮҮЛСЭХ өнэрэх, өрөвдөх, өршөөх; *нигүүлсэх сэтгэл; нигүүлсэн өршөөх.*

НИГШИХ идээний зүйлийн хувилж гашлан муудах, амт үнэр муухай болох; *нигшсэн аарц; эвгүй нигшсэн үнэр гараад байх чинь, юуны үнэр вэ? нигшсэн амт байна.*

НИГШҮҮЛЭХ нигшихийн үйлдүүлэх хэв.

НИГШҮҮРЭЛ нигшүүрэх үйлийн нэр; *нигшүүрэл төрөх.*

НИГШҮҮРЭЛТЭЙ нигшүүрвэл зохих зүйл бий; *нигшүүрэлтэй амт; нигшүүрэлтэй үнэр.*

НИГШҮҮРЭХ үл тааламжлах, дотор аягүй болох; жигших, дур гутах; *өвхөнд нигшүүрэх; амттанд нигшүүрэх; үг ярианд нигшүүрэх; үнэр танарт нигшүүрэх; үзэж хараад нигшүүрэх.*

НИГШЭЭХ нигшихийн үйлдүүлэх хэв.

НИДРҮҮЛЭХ 1. нидрэхийн үйлдүүлэх хэв; 2. нидрэгдэх.

НИДРЭГ 1. угаах юмыг тавьж үрэх нухах хэрэгсэл; *модон нидрэг; төмөр нидрэг;* 2. арьс элдэхэд нухах, нидрэх багаж.

НИДРЭГДҮҮЛЭХ нидрэгдэхийн үйлдүүлэх хэв.

НИДРЭГДЭХ нидрэхийн үйлдүүлэх хэв, юмыг нидрэг дээр нидрэх, хавиран нухах.

НИДРЭХ 1. юмыг юман дээр хүчтэй өрж нухах, юмыг юмаар харах хавирах; *арьс нидрэх; нидэрч нухах; нидэрч угаах;* 2. ш и л ж с э н цохих, дэлсэх.

НИДЧИХ олон удаа буюу байн байн нидрэх.

НИДЧҮҮЛЭХ нидчихийн үйлдүүлэх хэв.

НИЖГЭР сүртэй, том; *түүний хурим шиг нижгэр хурим болоогүй.*

НИЖГЭЭД тус бүрт нэг, тус тус нэг, хүн тутамд нэг, нэг нэг; *нижгээд сул морь хөтөлсөн; хүн бүр нижгээд хайрцаг юмтай; хүн тутамд уналга морь, ачлага тэмээ нижгээдийг олгох; сурагч нэг бүрт дэвтэр, харандаа нижгээдийг тавьж өгөв.*

НИЖИГНҮҮЛЭХ нижигнэхийн үйлдүүлэх хэв.

НИЖИГНЭХ түчигнэн, хүрчигнэн хүчтэй дуугарах; *тэнгэр нижигнэн дуугарч ширүүн бороо орлоо; гал нижигнэтэл асч байна; алга нижигнэтэл ташцагаав.*

НИЖИГНЭЭН шуугиан, түжигнээн.

НИЖЭЭД нижгээд.

НИЙ I дотнолон найралдсан, их л найралдсан нь; **ний найрал, ний самс х о р ш.; ний болох** (нэг гэрийн хүмүүс мэт болох).

НИЙ II: ний нуугүй санаа харамгүй, илэн далангүй, нуух хаах юмгүй; *ний нуугүй ярилцах; ний нуугүй итгэлцэх; ний нуугүй болох.*

НИЙГЛЭХ нийгэн болох, нийгэмчлэх, нийт дундын болгох.

НИЙГТГЭХ юмыг тэн тэнцүүлэн нийгэн адил болгох.

НИЙГТЭХ нийгэнд тэнцүү адил болох.

НИЙГЧЛҮҮЛЭХ нийгчлэхийн үйлдүүлэх хэв.

НИЙГЧЛЭХ нийчлэх, нийгэмчлэх, нийгмийн болгох.

НИЙГЭМ 1. нийгэмлэг; **нийгэм журам** (эв хамт нийгмийн ачийгэм-эдийн засгийн давхрагын анхны үе; *нийгэм журмын бүтээн байгуулалт*); **нийгмийн ухаан** (түүх, эртний судлал, эдийн засаг, хэл бичиг, утга зохиол зэрэг нийгэм, нийгэмлэгийн тухай шинжлэх ухаан; *нийгмийн ухааны салбар*); 2. нийгэн, даяар, бүгд, нийтээр; *нийгмээр оролцох ажил; нийгмийн хөрөнгө; нийгмийн өмч; нийгмийн мал; нийгэм тэгш; нийгэм даяар;* **нийгмийн хангамж** хөдөлмөрчдийг тахир татуу болох, нас өндөр болох, асрамжлах хүнгүйд хүрэх зэрэгт тэднийг улсаас тэтгэн туслах зардал төсөв); **Нийгмийг аюулаас хамгаалах яам** (улсын аюулгүй байдлыг хамгаалах яам); **нийгмийн үзэгдэл** (нийгмийн мөн чанарын гадаад илрэл, байдал); **нийгмийн гарал** (нийгмийн ямар анги, давхрага, ямар үндэстэн ястнаас төрсөн уг үүсэл); **нийгмийн хөрөнгө** (хувийн бишөмч, *нэгдэлчдийн нийгмийн хөрөнгө*); **нийгмийн ашиг** (хувийн биш, нийтийн ашиг).

НИЙГЭМЛЭГ 1. түүхийн тухайн хөгжлийн үед тохирсон үйлдвэрлэлийн тодорхой харьцаа, мөн материал үйлдвэрлэлийг явуулах тодорхой аргаар илрэх хүмүүсийн харьцааны цогц; *феодалын нийгэмлэг; хөрөнгөтний нийгэмлэг; нийгэм журмын нийгэмлэг; эв хамтын нийгэмлэг;* **нийгэмлэгийн суурь** (аливаа нийгмийн хөгжлийн тухайн үе дэх эдийн засгийн байгуулал); 2. ямар нэг зорилгоор нэгдсэн хүмүүс, мөн тийм хүмүүсийг удирдах байгууллага); *Эрдэм түгээх нийгэмлэгийн гишүүн; Хөдөлмөр нийгэмлэг; Монгол Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэгийн дэд дарга.*

НИЙГЭМЛЭХ нийгэмчлэх, нийтийн болгох.

НИЙГЭМЧЛҮҮЛЭХ 1. нийгэмчлэхийн үйлдүүлэх хэв; 2. нийгэмчлэгдэх.

НИЙГЭМЧЛЭГДЭХ нийгэмчлэхийн үйлдэгдэх хэв.

НИЙГЭМЧЛЭХ 1. нийгтгэх; *нийгэмчлэн олгох; нийгэмчлэн татварлах;* 2. нийгмийн болгох; *мал хөрөнгө нийгэмчлэх.*

НИЙГЭН бүгдээр, түгээмэл; *нийгэн даяар; ард нийгэнээр сонсов; үүл нийгэн бүрхэв.*

НИЙДЭМ нийт, даяар.

НИЙДЭМХИЙ бусдын юмыг дур мэдэн хэрэгсэгч; *нийдэмхий зантай хүн.*

НИЙДЭМХИЙЛЭХ нийдэмгий зан гаргах.

НИЙЛБЭР 1. нийлж нэгдсэн юм; *тооны нийлбэр; усны нийлбэр; замын нийлбэр;* 2. нийлэмж, тохиромж; *нийлбэр сайтай; нийлбэр муутай.*

НИЙЛГҮҮР нус нийхэд зориулан хийсэн сав буюу бөс юм; *нийлгүүр сав.*

НИЙЛГЭХ нийхийн үйлдүүлэх хэв.

НИЙЛЛЭГ тохиол, учрал; нийлсэн газар.

НИЙЛМЭЛ ҳолимол, хутгамал.

НИЙЛҮҮЛЭГ 1. нийлүүлэх үйлийн нэр; 2. мал хээлтүүлэг; *мал нийлүүлгийн компани гар нийлүүлэг; дур зоригийн нийлүүлэг.*

НИЙЛҮҮЛЭГЧ 1. юм хумыг бэлтгэн зэхэх, нийлүүлэх үүрэг бүхий хүн; 2. бялдууч, зусарч.

НИЙЛҮҮЛЭХ I 1. нийлэхийн үйлдүүлэх хэв, нийлэхэд хүргүүлэх; 2. хамтатгах, нэгтгэх; *хонь хурга нийлүүлэх; ус сүү нийлүүлэх; хүч нийлүүлэх;* **хувь нийлүүлэх** (тус тусын оногдох хувийг нэгтгэх); **дуу нийлүүлэх** (нэг зэрэг, зэрэг зэрэг; *дуу нийлүүлэн дуулж байв; дуу нийлүүлэн аашлав*); *холыг ойртуулж, хоёрыг нийлүүлэх* з ү й р; ☆ **нийлүүлэх гэрээ** (худалдах ба худалдан авах зэрэгт хоёр этгээд харилцан байгуулах тэмдэг бичиг); 3. ш и л ж с э н бэлтгэн хангах; *албан журмаар нийлүүлэх сүү тос; бараа нийлүүлэх; арьс шир нийлүүлэх;* 4. ш и л ж с э н бялдуучлах, зусардах, дагалхийлэх; *таалалд нийлүүлэх; байдалд нийлүүлэх.*

НИЙЛҮҮЛЭХ II хээлтүүлэх; *хуц нийлүүлэх; сайн үгсээны бухтай нийлүүлэх.*

НИЙЛҮҮЛЭХ III нийлэх II-ын үйлдүүлэх хэв, хурцлуулах; *хадууpаа сайн нийлүүлж аваад ир!*

НИЙЛҮҮЛЭЭЧ бялдуучлан дагалхийлэх хүн; *тэр чинь нийлүүлээч нь хэтэрсэн амьтан.*

НИЙЛҮҮР хавирч нийлдэг юм; *хутганы нийлүүр.*

НИЙЛЦ нийлэх чанар; *нийлц сайтай гурил.*

НИЙТЛЭГ түгээмэл; *нийтлэг чанартай.*

НИЙТЛЭГЧ 1. нийтэд дэлгэрүүлэгч; 2. сонин хэвлэлд бичигч; *өгүүлэл нийтлэгч.*

НИЙЛЭГ харилцан холбогдол бүхий задраг, хэсэг бусаг үзэгдэл юмыг нэгтгэн шинжлэх, баримт сэлтийг ерөнхийлөн дүгнэх шинжилгээний арга; 2. холимог юм.

НИЙЛЭЛ 1. нийлэх үйлийн нэр; 2. ямар нэг юмны холболдсон нийлсэн газар; 3. цэргийн хэсэг хэсэг ангиуд ба бусад биеэ даасан цэргийн нэгжээр бүрэлдсэн цэргийн нэгдэл, бүлэг; *танкийн нийлэл; цэргийн нийлэл;* 4. хэд хэдэн язгуур махбодийн атомаар бүтсэн молекултай бодис; *химийн нийлэл.*

НИЙЛЭЛДЭХ нийлэхийн үйлдэлдэх хэв; 1. хамтдах; 2. хутгалдах, холилдох.

НИЙЛЭЛТ 1. юмны нийлсэн газар; 2. нийлж тохиох.

НИЙЛЭЛЦЭХ нийлэхийн үйлдэлцэх хэв, харилцан зохицох, тохиролцох, зохирох.

НИЙЛЭМЖ нийс, зохис; *нийлэмж нь хир зэрэг байна?*

НИЙЛЭМЖГҮЙ нийсгүй, зохисгүй, нийцгүй, тохиромжгүй.

НИЙЛЭМЖТЭЙ нийс сайтай, зохистой, тохиромжтой, зохимжтой.

НИЙЛЭХ I нийцэх, зохицох, нэгдэх хамтрах, таарч тохирох; **эв нийлэх** (а. санаа явдал зохицон нэгдэх; *үйл ажлыг эв нийлж хийвэл бүтэх нь хялбар;* б. эвдэрсэн салсан юмны хэсгүүд эвтээ орох, тохирох; *хагархай аяга чинь эвээрээ нийлсэн үү?*); **санал нийлэх** (зөвшөөрөх, зөвт үзэх, санаа нэгдэх); **санаа нийлэх** (санаа бодол нийцэх, үйл ажил зохицох); **хэл нийлэх** (үг яриа харилцан тохирох; *хэлэлцээд хэл нийлэх, хэвтээд сүүж нийлэх*); **зам нийлэх** (явах зам, хийх үйл нэгдэх); **гар нийлэх** (үйл ажилд санаа нэгдэж хөдлөх); **хувь нийлэх** (тус тус юм гаргаж нэгдэх); **ганзага нийлэх** (а. сэтгэл санаа зохицох, нийцэх; б. үйл ажил таарч тохирох; в. явдлын хүний мөр зохицон, ажил үйл урмастай бүтэх); **зүс нийлэх** (гадаад үзэгдэл, зүс өнгө харилцан ижилсэх; *унасан морь, өмссөн хувцас нь зүс нийлж гарчээ*); **хоолой нийлэх** (дууны ая хөг, өнгө адилшин зохицох); **хөл нийлэх** (а. алхаа гишгээ харилцан тохирох; *жагсагчдын хөл нийлж ярс ярс алхална;* б. үйл явдлын зам мөр, арга, ажиллагаа тохирч таарах; *энэ хоёрын арга ажиллагаа хөл нь нийлж байна*); **ам нийлэх** (а. хоёр юмны ам уулзар харилцан тохирох; *энэ хоёрын ам яг нийлж байна; хананы ам нийлэхгүй байв;* б. үг яриа таарч тохирох); **баг нийлэх** (хоёр этгээд талцан тэмцэж наадах; *сурын баг нийлэх; баг нийлж шагаа харвах*); **нам нийлэх** (сэм хуйвалдах, нууц сүлбээлдэх; **нам нийлж, сэм хуйвалдах** х о р ш.); **ном нийлэх** (а. х у у ч и р с а н онолын маргаанд бэлтгэх зорилгоор хэд хэдээр хамтран ном үзэх; б. ном зохиолыг уг эхтэй нь тулган тохируулах); **бичиг нийлэх** (ямар нэгэн хуулбарласан бичиг зүйлийг уг эхтэй нь тулган унших); **хил нийлэх** (газар нутгийн зах хязгаар залгах; *улсын хил нийлэх; аймгийн хил нийлэх*); **хэрэг нийлэх** (засаг захиргааны талаар хоёр өөр газрын хооронд гарсан маш их зөрөлдөөнтэй хэргийг эцэс болгон шийдвэрлэхийн тул тус тусаас төлөөлөгч гаргаж хамтран шийдвэрлэх): **олон яс нийлэх** (ууц харцага сүүж ясдын уулзар нийлэлтийн газар).

НИЙЛЭХ II мэсийн зүйлийг хурцлан хавирах; *хутга нийлэх; хадуур нийлэх.*

НИЙНТЭГ айж бэмбэгнэх байдалд оруулах зүйл; *нийнтэгт дарагдах; олны сүрт нийнтэгт*

дарагдаад үг хэлж чадсангүй; багшийн дэргэд нийнтэгт автагдаад хөдөлж ч чадсангүй шүү.

НИЙНТЭГГҮЙ айж сүрдмээр байдал байсангүй.

НИЙНТЭГДЭХ сүрдэж бэмбэгнэх байдалд хүрүүлэх үйл учруулах.

НИЙНТЭГЛЭХ нийнтэг болгож сүр үзүүлэх.

НИЙНТЭГРЭХ нийнтэгт автагдан сүрдэхэд хүрэх.

НИЙНТЭГТЭЙ айж сүрдмээр байдал бий.

НИЙНТЭГШИХ айн сүрдэж зүрхших байдал гаргах.

НИЙС саная нийцэж зохицох нь; *нийс сайтай; нийс муутай.*

НИЙСГҮЙ харилцан саная нийлэхгүй, санаа зохицохгүй.

НИЙСЛЭЛ улсын нийслэлсэн хот, улсын төв хот; *нийслэл Улаанбаатар; Нийслэлийн хөдөлмөрчдийг сүү цагаан идээгээр хангах.*

НИЙСЛЭЛЛҮҮЛЭХ нийслэллэхийн үйлдүүлэх хэв.

НИЙСЛЭЛЛЭХ нийслэх.

НИЙСЛЭХ улсын төв хот болгох; *төвлөн нийслэсэн хот ажээ.*

НИЙСТЭЙ эе сайтай, нийцэрхэг зантай.

НИЙТ бүгд; *нийтийн сонгуулийн эрх; нийтийн хөрөнгө; нийтийн байр; нийтэд зарлан мэдэгдэх;* **олон нийт** (олон түмэн); *олон нийтийн ажил; нийтийн орон сууц; нийтийн санал сэтгэл.*

НИЙТГҮҮЛЭХ нийтгэхийн үйлдүүлэх хэв.

НИЙТГЭМЭЛ нийтгэсэн, томсон юм.

НИЙТГЭХ имрэн эрчилж томох; *утас нийтгэх.*

НИЙТЛҮҮЛЭХ нийтлэхийн үйлдүүлэх хэв, нийт болгох.

НИЙТЛЭГДЭХ нийтлэхийн үйлдэгдэх хэв.

НИЙТЛЭХ нийтэд тараах, хэвлэн тараах, нийтээр болгох; *сонинд нийтлэх; хэвлэн нийтлэх; нийтлээгүй дугаар; нийтлэхийн өмнө.*

НИЙТЭХ ний болох, нийгэм дундын болгох.

НИЙХ нусаа огоорон гаргах; *нус нийх.*

НИЙЦ 1. зүй, зохис; *нийц сайн; нийц муу;* 2. эе найрал, нийлэмж.

НИЙЦВЭР нийц, нийлэмж.

НИЙЦВЭРГҮЙ нийцэж зохицож чаддаггүй.

НИЙЦВЭРТЭЙ нийцэж зохицохдоо сайн, эвцээхэн.

НИЙЦГҮЙ 1. зохисгүй, зүйгүй; *нийцгүй хоол идээ;* 2. эе найрамдалгүй; нийлэмжгүй; *хүнтэй нийцгүй.*

НИЙЦТЭЙ нийц сайтай, нийцэхдээ сайн.

НИЙЦҮҮ байдалд зохицуу, эе эв сайтай.

НИЙЦҮҮЛЭХ нийцэхийн үйлдүүлэх хэв, нийлүүлэх, тохируулах; *санаанд нь нийлүүлж явбал болох нь тэр.*

НИЙЦЭТ нийц бүхий, нийцтэй.

НИЙЦЭХ нийцтэй болох, зохицох, нийлэлцэх; *зүйд нийцэх; хууль дүрэмд нийцэх; зан заншилд нийцэх.*

НИЙЧЛЭХ манай танайгүй болох, чи би гэж ялгахгүй нийтэх; *тэр хоёр ёстой нийчилсэн хүмүүс байгаа юм.*

НИКЕЛ хувилахуй ухааны махбод, хөнгөн цагаан мэт өнгөтэй, хялбар хайлдаггүй, техникт ихээхэн хэрэглэдэг төмөрлөг.

НИКЕЛДЭХ никелээр юмыг өнгөлөх, түрхэх; *никелдсэн ор.*

НИЛ I: **нил хийх** аягүй үнэртэх; *мах бээчихсэн юм үү, нил хийсэн үнэр гарч байна.*

НИЛ II: **нил цэцэг** у р г а м а л ягаан цэцэгтэй өвсөрхөг ургамал.

НИЛЧИГНЭМ: нилчигнэм халуун төөнөм халуун.

НИЛЭГ аягүй үнэр.

НИЛЭЭД бага бишү, зэгсэн, овоо; *нилээд их цас оржээ; нилээд олон хүн байв; нилээд сайн эд; нилээд дутагдал бий.*

НИЛЭЭН нилээд.

НИМБЭГ у р г а м а л мөнх ногоон модонд ургадаг анхилам үнэртэй, хатуу хальстай жимс; *нимбэгийн мод; нимбэгийн хучил.*

НИМГЭДҮҮЛЭХ нимгэдэхийн үйлдүүлэх хэв, хэтэрхий нимгэн болгох, нингэдүүлэх.

НИМГЭДЭХ хэтэрхий нимгэн учир тохиромжгүй болох, нингэдэх.

НИМГЭЛҮҮЛЭХ нимгэлэхийн үйлдүүлэх хэв, нимгэн болгуулах, нингэлүүлэх.

НИМГЭЛЭХ нимгэн болгох, нингэлэх.

НИМГЭН 1. зузаан гэдэггэй эсэргүүцэлдсэн утга, нингэн; *нимгэн банз; нимгэн дээл; цаас нимгэн боловч чичихээс наашгоордоггүй хүн сэцэн боловч хэлэхээс наашмэддэггүй* х у у ч. 2. өчүүхэн, арвин биш, их биш, *малын тарга нимгэн байна; хөрөнгө нимгэн; мэдлэг нь нимгэн байна.*

НИМГЭРҮҮЛЭХ нимгэрэхийн үйлдүүлэх хэв, нимгэрэхэд хүргүүлэх, нингэрүүлэх.

НИМГЭРЭХ 1. нимгэн болох, нингэн болох; *үүл нимгэрч байна;* 2. бага болох, хоосрох; *хөрөнгө нь нимгэрчээ.*

НИМГЭСГЭХ улмаар нимгэн болгох.

НИМГЭСҮҮЛЭХ нимгэсэхийн үйлдүүлэх хэв.

НИМГЭСЭХ улмаар нимгэн болох.

НИМГЭТГЭХ улмаар нимгэн болгох, нимгэсгэх.

НИМГЭТҮҮЛЭХ нимгэтэхийн үйлдүүлэх хэв.

НИМГЭТЭХ улмаар нимгэн болох, нимгэсэх.

НИМГЭХЭН арай нимгэн, нингэхэн.

НИНГЭДҮҮЛЭХ нингэдэхийн үйлдүүлэх хэв, нимгэдүүлэх.

НИНГЭДЭХ хэтэрхий нингэн болох, нимгэдэх.

НИНГЭЛҮҮЛЭХ нингэлэхийн үйлдүүлэх хэв, нимгэдүүлэх.

НИНГЭЛЭХ нингэн болгох, нимгэлэх.

НИНГЭН нимгэн.

НИНГЭРҮҮЛЭХ нингэрэхийн үйлдүүлэх хэв, нингэн болгуулах, нимгэрүүлэх.

НИНГЭРЭХ нингэн болох, нимгэрэх.

НИНГЭХЭН арай нингэн, нимгэхэн.

НИР: **нир хийх** нүргэлсэн огцом чимээ гарах; *хураалгатай банз нурж нирхийн буув;* **нир нир хийх** (нүргэлэх доргих чимээ байн байн гарах; *толгой нир нирхийн сүрхий өвдөнө);* **нир нар хийх** (юмны нүргэлж доргилсон чимээ үргэлжлэн гарах).

НИРВААН нярваан.

НИРГҮҮЛЭХ ниргэхийн үйлдүүлэх хэв.

НИРГЭЛТ ниргэх үйлийн нэр.

НИРГЭХ 1. цахилгаан цохих, аянга дайрах; *цахилгаан ниргэх; аянга ниргэх; тэнгэр ниргэх;* 2. цохих, дарах; *бууутныг бут ниргэх; уруутныг устган ниргэх.*

НИРД: **нирд хийх** юмны нүргэлсэн сочмог хатуу чимээ гарах.

НИРХИЙХ хөгжилдөх; *нирхийтэл инээлдэв; нирхийтэл босцогоов.*

НИРЧИГНЭХ нижигнэх, нир нир хийх.

НИСВААНИС нясвааняс.

НИСГҮҮЛЭХ нисгэхийн үйлдүүлэх хэв.

НИСГЭХ нисэхийн үйлдүүлэх хэв, нисэхэд хүргүүлэх; *тагтаа нисгэх; онгоц нисгэх.*

НИСГЭГЧ нисэх онгоцны жолооч.

НИСГЭЛ нисэн халих юм; *нисгэл бөмбөлөг;* **нисгэл шувуу** (цаасан шувуу).

НИСЛЭГ нисэх үйлийн нэр; *нислэг хийх.*

НИСЭГЧ нисдэг юм.

НИСЭЛТ нисэх үйлийн нэр; *нисэлтийн хурд.*

НИСЭХ 1. жигүүртэн буюу жигүүртэй юмны агаарт халин зорчих; *бүргэд нисч явна; би Москвагаас нисч ирсэн;* 2. өндөр юмаи дээрээс халин үсрэх; *би хадан дээрээс нисч үхэх шахав; өндрөөс нисч байна гэж зүүдлэв;* 3. маш хурдлах; *хээр морьтой хүн нисэх мэт довтлов;* **нисэх онгоц** (далавч жигүүр бүхий нисэх аппарат); **нисэх хөлөг** (нисэх онгоц); **нисэх хүчин** (улсын зэвсэгт хүчний нэг зүйл, агаарын цэрэг); **нисэх тэрэг** (нисэх онгоц, вертолет); **нисэх талбар** (нисэх онгоцны буух, зогсох газар); **нисэх бөмбөг** (агаарт дэгдүүлэн хөөргөх хальсан бөмбөг); **нисэх од** (жирэвхийн өнгөрөх од); **нисэх онгоцны хөлөг** (нисэх онгоцны буух, нисэх талбай бүхий тэнгэсийн цэргийн хөлөг); **нисэх онгоцны буудал**

(нисэх онгоцны буух, нисэх талбай бүхий зогсоол); **нисэх алт** (зурах будахад наалдуулан хэрэглэх маш нимгэн цаасны адил боловсруулсан алт, цаасан алт ч гэдэг); **нисэх үнэг** амьтан (ойд оршдог, бие нарийн урт, өмнөд хөлийн муруйгаас гуя хүртэл арьсан жигүүртэй, нэг модноос нөгөө модонд ташин нисдэг нэгэн зүйл амьтан); **нисэх хулгана** амьтан (сахлаг цагтуусад оршдог, зурамтай төстэй болоод нисэх үнэгний адил арьсан жигүүртэй нэгэн зүйл амьтан).

НИТ нүүрний өмнө, нүдний өмнө; **нүүрний нит** (харсаар байтал, нүүр дээр, нүдэн дээр).

НИТГЭЛ өтгөрөн язмагтсан юм; *цайны нитгэл; шөлний нитгэл.*

НИТГЭЛРЭХ нитгэл болох.

НИТГЭЛТЭХ нитгэлтэй болох, нитгэл тогтох.

НИТГЭЛШИХ нитгэлийн шинжтэй болох.

НИТГЭРҮҮЛЭХ нитгэрэхийн үйлдүүлэх хэв, нитгэрэхэд хүргүүлэх.

НИТГЭРЭХ 1. нийтгэн эрчилсэн зүйлийг үтрэн шувтарч тэгш жигд эрчтэй болгох; *утас нитгэрэх; дээс нитгэрэх;* 2. иртэй юмаар хусч арилгах; *арьс нитгэрэх; хянгараар нитгэрэх;* 3. шилжсэн арьс зулгалах, шалбалах; *эмээлийн бүүрэгт гуяа нитгэрч орхилоо;* 4. няслан, хуруун дээгүүр эргүүлэх; *сумныхаа шулууныг шалгаж нитгэрэн байв.*

НИТГЭЧИХ байн байн нитгэрэх.

НИТЭГ шингэн юмнаас тунаж гарсан өтөг хувь; *айргийн нитэг;* нитгэл ч гэдэг.

НИТЭГРЭХ нитэг болох.

НИЧИГНЭХ ихээхэн дуу чимээ тасралгүй дуугарах, нижигнэх; *тэнгэр ничигнэх; бөмбөр ничигнэв; алга ничигнэтэл ташив.*

НИШИНГЭ чихэр өвс.

НОВ хүч нэмэгдүүлэх үг; *нов ногоон.*

НОВШ 1. хог; **хог новш** хорш.; 2. шилжсэн гэрийн хэрэгтэй, хэрэггүй элдэв хэрэгсэл; *новш ихтэй айл.*

НОВШИРХОГ новширхуу.

НОВШИРХУУ хог новш ихтэй.

НОВШРОХ юм эмх замбараагүй хөглөрч байх, новш их болох; *новширсон айл байна билээ.*

НОВШРУУЛАХ новшрохын үйлдүүлэх хэв, новш болгох.

НОВШТОХ новш болох.

НОГДОЛ ногдсон юм, оногдол; *сүүний ногдол; махны ногдол.*

НОГДОХ оногдох.

НОГДУУЛАХ ногдохын үйлдүүлэх хэв, оногдуулах.

НОГОО 1. бут модонд үл тооцогдох гандаагүй өвсөн ургамал; *ногоо цухуйж байна; зүлгэн ногоо;* **ногоо хөөх** (хавар ногоо цухуйх үеэр мал ногоо эрж билчээрлэх); *нар дээр байхад, ногооны сөлтэй байхад* зүйр; 2. хоолонд хэрэглэх үрсэг ба ногоон ургамал; *идэшний ногоо; ногоотой хоол; ногоотой шөл;* **ногоо дарах** (ногоог давслан хадгалах); **ногооны газар** (идэшний ногоо тарих, хадгалах, худалдах газар); **ногооны хашаа** (ногоо тарьсан газрын гадуурхи хашаа хамгаалалт); **ногооны зоорь** (ногоо агуулж хадгалах газар).

НОГООВОР I хар туяатай ногоон өнгө.

НОГООВОР II: **ногоовор хөгц** амьтан нүдний цэцгий хар, шар зажууртай, толгой хүзүү ар жигүүр бүрэн ногоон алаг нэгэн зүйл бялзуухай.

НОГООВОРХОН баахан ногоовор.

НОГООВТОР цайвархан ногоон өнгө.

НОГООДОХ хэтэрхий ногоон болох.

НОГООДУУЛАХ ногоодохын үйлдүүлэх хэв, хэтэрхий ногоон болгох.

НОГООЖИХ ногоотой болох.

НОГООЖУУЛАХ ногоожихын үйлдүүлэх хэв; ногоожуулах зүлэгжүүлэх.

НОГООЛДОЙ амьтан уд модны навчтай адил ногоовторхон өнгөтэй нэгэн зүйл бялзуухай.

НОГООЛИН зэвийн бал.

НОГООЛОХ I малд ногоо элбэг дэлбэг идүүлэх; **ногоолж цагаалах** (мал ногоо идэж, цагаан идээ дэлгэрэх).

НОГООЛОХ II ногоон болгох.

НОГООН гандаагүй ногоо, навчин буюу оюугийн мэт өнгөтэй; *ногоон зүлгэн дээр; ногоон өнгийн будаг;* **ногоон хас** (өнгө нь оюу мэт чулуу); **ногоон өвс** (ногоог хадаж хатаасны хойно уг өнгөөр бүхий өвс): **ногооны хөөнгө** (ногоо ургах үест агаарт татах цэнхэр

униар); **ногоон цай** (шахмал цай); **ногоон цээл** (эрэглэсэн гүн ус); **ногооны буурцаг** у р г а м а л (газраар үргэлжлэн ургадаг, навч буурцаг хонгорцог, буурцгийн навч хонгорцогтой адил нэгэн зүйл өвс); **ногоон буурцаг** у р г а м а л (эрс буурцгийн нам, шиш амуугаас баахан том, ногоон өнгөтэй нэгэн зүйл үр); **ногоон толгойт** а м ь т а н (нэгэн зүйл соно ялаа); **ногоон галуу** а м ь т а н (өд өрөвлөг ногоон хал мэргэн); **ногоон тоть** а м ь т а н (шар тотьтой адил, толгой умруу ар жигүүр цөм ногоон, жигүүрийн уг шар нэгэн зүйл тоть; хүзүү улаан, ар жигүүр цөм ногоон тоть бас байдаг); **ногоон доожинч** а м ь т а н (доожинч бялзуухайгаас том, чандар ногоон, дотор шар, модонд дүүжлэх дуртай нэгэн зүйл бялзуухай); **ногоон хөдх** а м ь т а н (янз байдал нь хөхөөтэй адил, хар толгойтой, бие ногоон, ар нь элгэн өнгөтэй, шилбэндээ ноолууртай нэг зүйл шувуу); **ногоон мэлхий** а·м ь т а н (морин мэлхийгээс жижигхэн, ногоон өнгөтэй нэг зүйл мэлхий); **ногоон хүрэлзгэнэ** (голио).

НОГООРОХ 1. ногоон болох, ногоон өнгө бүрхэх; *мод ногоорох; мантууны гурил ногоорох; ногоорч харагдах; газар ногоорох;* 2. ногоон юм шиг үзэгдэх; *ногоорсон их ус;* 3. өнгө нь хувилж гутах; *мах ногоорох;* 4. гөлрөх, дүйрэх; *ногоортлоо согтох.*

НОГООРУУЛАХ ногоорохын үйлдүүлэх хэв, ногоон болгох; *хот ногооруулах ажил.*

НОГООХОН баахан ногоон.

НОГООЧИН ногоо тарих ажил эрхэлдэг хүн.

НОГТ морины толгойд зүүх гархи зуузайгүй оосор; *дээсэн ногт; суран ногт; хар морь ногоон ногттой* о н ь с г о *номхон морины чинь ногт болъё, догшин морины чинь чөдөр болъё* (үлгэр).

НОГТЛОГДОХ ногтлохын үйлдэгдэх хэв.

НОГТЛОХ 1. малд ногт өмсгөх, зүүх; *морь ногтлох;* 2. юм хумыг хэдэн тийш нь солбицуулан баглах, уях; *ногтолж баглах; ногтолж уях.*

НОГТЛУУЛАХ ногтлохын үйлдүүлэх хэв.

НОГТМОЛ хөгширч соёо нь ороосон бодон; **ногтмол нугас** а м ь т а н (янз байдал нь боржин нугасанд адил болоод арай жижиг нэгэн зүйл шувуу).

НОГТОС гөрөөсний намар цагийн үс нохой арьс.

НОГТРУУ а м ь т а н ятуу шиг, өнгө шаравтар эрээн, элэгний гус хар толботой, нисэхдээ их чимээтэй нэгэн зүйлийн шувуу.

НОГУУЛ шилүүсний зулзага.

НОДЛИН ноднин.

НОДНИН өнгөрсөн жил; *ноднин жил; ноднин намар; нодниноос эхлэн...*

НОЁГТОЙ 1. ноён хүний гэргий, хатан, эхнэр; 2. ноён эмэгтэй.

НОЁЛОГ 1. ноёрхог, ноёрхуу; 2. уулын гол өндөрлөг; *ноёлог уул; Алтайн ноёлог өндөр нь болох.*

НОЁЛОГДОХ ноёлохын үйлдэгдэх хэв, бусдад ноёлуулах.

НОЁЛОХ 1. эзэрхэх, түрэмгийлэх, илүү гарах, давамгай байх; *хүчээр ноёлох ноёлж байгаад хожиж орхив;* 2. ихэнх хувийг эзлэх, ноёрхох; *ноёлох хэсэг нь „Орхон" үүлдрийн хонь байв;* 3. дээрэнгүйлэх; *чи над ноёлох хэрэггүй.*

НОЁЛУУ эзэрхэн ноёлох зантай.

НОЁЛУУЛАХ 1. ноёлохын үйлдүүлэх хэв; 2. ноёлогдох; *би ч дандаа ноёлуулж явдаг хүн.*

НОЁН 1. эзэн, эрх сүрээр даран дарангуйлагч этгээд; *ноёнтой өстэй бол хонгогүй, нохойтой өстэй бол хормойгүй* з ү й р; *ноён урваач, нохой шарваач* з ү й р; *ноён хүнийг итгэж болохгүй, нойтон модыг түшиж болохгүй* з ү й р **ноён нуруу** (юмны дам нурууны дээдэх нуруу; *байшингийн ноён нуруу; хаалганы ноён нуруу);* **ноён орой** (юмны хамгийн голлох өндөрлөг буюу оргил; *барилгын ноён орой; уулын ноён орой);* **ноён шиш** у р г а м а л (будааны нэг төрөл, өндөр ургана, шар цагаан хоёр зүйл бий; цагааныг идшинд хэрэглэнэ, шарыг малын тэжээл ба архи нэрэхэд хэрэглэнэ); 2. шатрын нэг дүрс; *ноёноо зайлуулаарай, шалж байна шүү!*

НОЁРХОГ ноёрхох зантай, ноён зантай.

НОЁРХОЛ ноёрхох үйлийн нэр; *ноёрхол нь хэтэрсэн этгээд; хөрөнгөтний ноёрхлыг устгах.*

НОЁРХОХ 1. эзэрхэн захирах, дээрэнгүйлэн захирах, ноёлох; 2. ш и л ж с э н давамгайлах; ихэнх хувийг эзлэх; *далай дээр ноёрхох; ноёрхох анги.*

НОЁРХУУ ноёрхог.

НОЁРХУУЛАХ 1. ноёрхохын үйлдүүлэх хэв; 2. ноёрхогдох.

НОЁХОН авхай, ноёны охин.

НОЖИД егөө, хорлол.

НОЖИДЛОХ егөөлөх.

НОЖИДТОЙ егөөтэй.

НОЗООРОХ халуун дулааны зэрэгт бие хүндрэх, залхуу хүрэх; *дулаан өрөө дотор нозоорч орхив; хувцас хүнддэж бие нозоорood байна.*

НОЗООРУУЛАХ нозоорохын үйлдүүлэх хэв.

НОЙР I тогтмол хугацаанд мэдрэхүй бүрмөсөн буюу заримдаг зогсон амарч, нам гүм болох физиологийн ахуй байдал; **нойр авах** (унтах); **нойр хүрэх** (нойр ирэх, эрхгүй унтахад хүрэх); **нойр ханах** (унтаж гүйцэх, ханатлаа унтах); **нойр хулих** (түр сэрж, түр унтах); **нойр хулжих** (нойр сэргэж, унтаж чадахгүй болох); **нойр сэргэх** (нойр хүрэхээ байж сэргэлэн болох); **нойр дутуу** (нойр ханаагүй); **нойр сайтай** (а. сайхан унтдаг; б. сэргэг нойртой); **нойр муутай** (а. унтахыг тэвчиж чадахгүй, их унтдаг; б. дутуу унтсан, ханатал унтаж чадаагүй; в. нойр нь хүрэхдээ муу); **нойрны эм** (унтуулах эм) **нойр ихтэй** (унтамхай, их унтдаг); **нойр багатай** (сэргэг, хөнгөн унтдаг, бага унтдаг); **нойр сэргэг** (хөнгөн нойртой, хялбархан сэрэмтгий); *нойрноос морио, чөмөгнөөс хутгаа з ү й р.*

НОЙР II амьтны гэдэсний хажуугаар нааладаж байдаг булчирхай мэт гонзгой юм.

НОЙРГҮЙ 1. бага нойртой; 2. унтаагүй.

НОЙРМОГ нойроос сайтар сэргэж чадаагүй; *дөнгөж сэрээд нойрмог байлаа.*

НОЙРМОГЛОХ нойрмог байдал гаргах; *шөнө орой нойрмоглон суув.*

НОЙРМОГЛУУЛАХ нойрмоглохын үйлдүүлэх хэв. нойрмог болгох.

НОЙРСОХ унтахын хүндэтгэл; *хүүхэд нойрсож байна.*

НОЙРСУУЛАХ нойрсохын үйлдүүлэх хэв.

НОЙРТ нойр бүхий.

НОЙРТОЙ 1. нойр маш ихтэй; 2. ханатлаа унтсан.

НОЙТ чийг; **чийг нойт** х о р ш.; *агаарын нойт.*

НОЙТДОХ хэтэрхий нойтон болох.

НОЙТЛУУЛАХ нойтдохын үйлдүүлэх хэв.

НОЙТЛОХ нойтон болгох, чийглэх.

НОЙТЛУУЛАХ нойтлохын үйлдүүлэх хэв, нойтон болгуулах, чийглүүлэх.

НОЙТОВТОР баахан нойтон мэт, чийгвэр.

НОЙТОГНОХ 1. нойтон болгох; чийглэх; 2. ш и л ж с э н улиглах, баширлах.

НОЙТОН хуурайн эсрэг утга, үлэмж чийгтэй, усархаг, устай; *нойтон алчуур; нойтон оо нойтон мод;* **нойтон хамуу** (нэг зүйлийн хамуу өвчин); **нойтон хамуу оргих** (авд салахгүй байх).,

НОЙТРОХ нойтон болох.

НОЛ: **нол магнаг** алтан саагаар нэхсэн нэгэн зүйлийн торгомсог бараа.

НОЛГО I: **нолго баяжих** маш их баян болох.

НОЛГО II бөө нарын ташаандаа зүүж сэжин дуугаргах төмөр хонгио.

НОЛГОЙТ а м ь т а н янз байдал нь барстай адилхан, бие цагаан, үс нь гахайн үстэй адил адууны сүүл шиг сүүлтэй нэгэн зүйл гөрөөс.

НОЛИГ нуршин үгтэй, нуршуу.

НОЛИГЛОХ нуршлан хэлэлцэх, нурших, улиглах.

НОЛОЛДОХ шувууны тачаах.

НОЛОМ алтан утсаар ар гаргаж хийсэн хоргой мэт торго.

НОЛОРВОС а м ь т а н ирвэстэй адилхан бөгөөд ногоовор үстэй нэгэн зүйл амьтан.

НОЛЦГОР 1. яс чанар сайн биш; *нолцгор дурдан; нолцгор бөс;* 2. дорой, яданги; *нолцгор биетэй хүүхэд; нолцгор хүн.*

НОЛЦОЙХ нолцгор болох.

НОЛЧГОР номхон буурай; *нолчгор номхон зантай хүн харагддаг юм.*

НОМ 1. бичиг, сударь; **ном бичиг, ном сударь** х о р ш.; *ширээн дээр ном дэлгэж суув; захидлыг номын завсарт хавчуулжээ; унших ном байна уу? хятад ном; орос ном; номын худалдаа;* **номын сан** (ном бичгийг нийгмийн хэрэгцээнд зориулан цуглуулж цогцолсон газар; *хотын номын сан; нийтийн номын сан);* **номын санч** (номын сангийн ажлын талаар мэрэгжсэн ажилтан); **ширээний ном** (үргэлж хэрэглэж байдаг ном; *энэ лавлах бичиг бол миний ширээний ном);* **ном зүй** (номын жагсаалт, **заалт хийх тухай эрдэм шинжилгээний арга**

зүй); **ном зүйч** (ном зүйн ажилд мэрэгжсэн хүн): **ном хийх** (ном зохиох); **ном нийлэх** (хамтран ном үзэх, унших); **номын ах** (урьд сургуульд орогсод); **номын дүү** (хожид сургуульд орогсод); **ном барлах** (номыг бараар хэвлэн гаргах); **номын хаяг** (номын нэр); **номын шүүмж** (тухайн номын сайн муу болохыг дүгнэсэн үнэлэлт); **ном хаялцах** (аль нэгэн сэдэв асуудлаар маргалдах); 2. эрдэм, сургууль; **эрдэм ном** х о р ш.; *ном сурах; ном заалгах; эрдэм ном сур! номдоо муу боловч цавтаа сайн;* **ном үзэх** (сургууль хийх, бичиг сурах).

НОМГОРОХ номгон болгох, номхрох.

НОМГОРУУЛАХ номгорохын үйлдүүлэх хэв, номгон болгох, номхруулах.

НОМГОТГОГЧ номхон болгогч.

НОМГОТГОХ номгон болгох, номхотгох.

НОМГОТГУУЛАХ номготгохын үйлдүүлэх хэв, номхотгуулах.

НОМГОЧЛОХ номхныг шилэх, номхон байдлыг ашиглах.

НОМГОЧЛУУЛАХ номгочлохын үйлдүүлэх хэв, номхочлуулах.

НОМЕР дугаар; **номер дугаар** х о р ш..

НОМЕРЛОХ номертой болгох, дугаарлах.

НОМЕРЛУУЛАХ номерлохын үйлдүүлэх хэв, дугаарлуулах.

НОМИН I сайхан хөх цэнхэр өнгөтэй нэгэн зүйл эрдэнийн чулуу, гоёл чимгийн зүйлд хэрэглэнэ; *номин чулуу нь гоё хөв.*

НОМИН II: **сохор номин** а м ь т а н янз байдал нь зурамтай адилхан, жижиг, нүд бяцхан, хөл охор, хумс нь урт, газарт гулдрин орших нэгэн зүйл оготно.

НОМЛОГДОХ номлохын үйлдэгдэх хэв.

НОМЛОГЧ ном номлох хүн.

НОМЛОЛ сургаал, зохиол; *Марксын номлол; эрдэмтэн мэргэдийн номлол.*

НОМЛОХ 1. ном номлохыг сэнхрүүлэх, мэдрүүлэх; 2. учир чанарыг ухуулан заах, сургах; *аав намайг зөндөө номлож гарав.*

НОМЛУУЛАХ 1. номлохын үйлдүүлэх хэв; 2. номлогдох; *багшаараа номлуулж номлуулж ирэв.*

НОМОЙ дорой, номхон; **номой дорой, номой номхон, номой нонж** х о р ш..

НОМОЙДОХ хэтэрхий номой болох.

НОМОЙЛОХ алгуур назгай байдал гаргах.

НОМОЙРОХ номой болох.

НОМОЙТОХ номой байдал гаргах.

НОМОН номин II.

НОМОРХОХ 1. номчирхох; 2. номтойгоо гайхуулах.

НОМХДОХ хэтэрхий номхон болох, номгодох.

НОМХОМСОГЛОХ засдаг хуурмаг зангаар номгон байдал гаргах.

НОМХОН догшины эсрэг утга; 1. авир ааш ширүүн биш, төлөв намжуу; *номхон амьтан; номхон хүний дотор нум сум бий* з ү й р; 2. усгал, дөлгөөн: **номхон дөлгөөн** х о р ш..

НОМХОТГОЛ номхотгосон нь; номхон болгох үйлийн нэр, номготгосон нь.

НОМХОТГОХ 1. номхотохын үйлдүүлэх хэв, номхон болгох, номготгох, *догшин хэрцгийг номхотгох; хатан хатууг номхотгох;* 2. ерөндөглөх, хоргүй болгох; *хорыг арилгаж номхотгох.*

НОМХРОХ номхон болох, *эмнэг морь номхров.*

НОМХРУУЛАХ номхрохын үйлдүүлэх хэв, номхон болгох, номгоруулах.

НОМХТОХ номгорох.

НОМХОЧЛОХ номой номхон байдлыг далимдуулах; *хэтэрхий номхочилж байна.*

НОМХОЧЛУУЛАХ 1. номхочлохын үйлдүүлэх хэв; 2. номхочлогдох.

НОМЧ 1. ном хийгч, ном зохиогч; 2. номын утга учрыг сайн мэдэгч.

НОМЧИРХОГ номчирхон зан гаргадаг.

НОМЧИРХОХ номч байдал гарган аашлах.

НОМЧИРХУУ номчирхог зантай.

НООГДВОР оногдол, ногдсон юм; ногдвор.

НООГДОЛ оногдол; *ноогдол хуудас; ноогдлоос чөлөөлөгдөх.*

НООГДОХ оногдох, ногдох.

НООГДУУЛАХ ноогдохын үйлдүүлэх хэв, оногдуулах, ногдуулах; *алба ноогдуулах.*

НООЛОЛДОХ ноолохын үйлдэлдэх хэв; **ноцолдох ноололдох** х о р ш..

НООЛОЛДУУЛАХ ноололдохын үйлдүүлэх хэв.

НООЛОЛЦОХ ноолохын үйлдэлцэх хэв, бусдын хамт ноолох.

НООЛОЛЦУУЛАХ ноололцохын үйлдүүлэх хэв.

НООЛОХ юмыг байн байн барьж нухлан үнгэх, ноцолдох; *хүүхэд ноолсоор байгаааd номхон болгожээ; номхон тэмээ ноолоход амар з ү й р; нохой ноололдож байна.*

НООЛУУЛАХ 1. ноолохын үйлдүүлэх хэв; 2. ноологдох.

НООЛУУР 1. зарим амьтны зөөлөн унгарил үс; *ямааны ноолуур; нохойн ноолуур;* 2. ноолууpаар хийсэн юм; *ноолуур цэмбэ; ноолуур дэр.*

НООРОГ I бичиг зохиолын навтраг, эх; *бичгийн ноорог; цоохор навтраг ч гэдэг.*

НООРОГ II ноорхой болсон юм; *дээлийн ноорог.*

НООРОГЛОХ ноорог болгох; *бичгийн эх нооpоглох.*

НООРОГЛУУЛАХ нооpоглохын үйлдүүлэх хэв.

НООРОНХОЙ ихэд урагдаж навтарсан нь; *нооронхой дээл; нооронхой майхан.*

НООРОХ 1. гуужиж салбаран унжих; *хонины ноос ноорох;* 2. ш и л ж с э н ихэд урагдаж навтрах; *дээл маань ноорч гүйцэв.*

НООРС шувууны чандрын хэмхдэг; **ноорс шаа** (нэг зүйл сиймхий нэхсэн торго); **ноорс торго** (бялзуухайн ноосоор нэхсэн торго).

НООРХОЙ нооронхой.

НООС (ОН) 1. адгуусан амьтны биеийг бүрхсэн үе; *хонины ноос; тэмээний ноос;* **үс ноос** х о р ш.; 2. мөнхүү ноосоор хийсэн эд эдлэл; *ноосон бээлий; ноосон даавуу.*

НООСОРХОГ ноос ихтэй; *ноосорхог хонь.*

НООСОРХУУ нилээд ноосорхог.

НООСРОХ эд бөс элэгдэж ноос мэт зөөлөн унгарил болох.

НООХОЙ мэрэгч нүүний амьтны хэвтэш; *оготны ноохой; хулганын ноохой.*

НООХОЙЛОХ ноохой засах, ноохой хийх; *нүүхэд нь авдар дор оготно ноохойлсон байв; гэрийн бүрээсний завсар ноохойлсон байв.*

НОРГОХ норохын үйлдүүлэх хэв, нойтон болгох; **хоолой норгох төдий** (уух юмны маш бага; *хоолой норгох төдий юм уув);*

НОРГУУЛАХ норгохын үйлдүүлэх хэв, нойтон болгуулах.

НОРМ 1. хууль болгож тогтоосон, нийтээр дагаж журамлах хэв хэмжээ; *шүүх цаазны норм; утга зохиолын хэлний норм;* 2. ямар нэгэн юмны тогтоосон хэмжээ, дундач хэмжигдэхүүн; *гүйцэтгэх норм; тунадас буух норм.*

НОРМЛОХ норм тогтоох, нормтой болгох.

НОРМ нормлосон мод; *норм мод.*

НОРОМЛОХ цавчсан дүнз гуалин модыг нэгэн газар хэвтүүлэн овоолох; *мод норомлох.*

НОРОХ нойтон болох, чийг үс нэвтэрч шингэх; *бороонд норох; усанд норох.*

НОРХОЙ охор үс, нявталхан үс; *норхой үстэй арьс.*

НОТ I 1. хөгжмийн авианы зурмал дүрслэг; *ноттой цаас;* 2. зурмаг дүрслэн гаргасан хөгжмийн зохиолын эх бичиг; *нотоор наадах; дууны нот.*

НОТ II нэгэн улсын засгийн газраас нөгөөд явуулах дипломат бичиг; *эсэргүүцлийн нот.*

НОТ III бат, нут; **бат нот** х о р ш..

НОТАРИАТ гэрээ гэрчлэх газар; *нотариатаар батлуулах.*

НОТАРИУС аливаа гэрээ хэлэлцээг албан ёсоор гэрчлэгч тушаалтан.

НОТЛОГДОХ нотлохын үйлдэгдэх хэв, батлагдах, нутлагдах; *гэмт хэрэг үйлдсэн нь үүгээр нотлогдож байна.*

НОТЛОХ батлах, бат болгох, нутлах, нутболгох.

НОТЛУУЛАХ нотлохын үйлдүүлэх хэв, нутлуулах.

НОТОД батад, нутад; *нотод баримтлах; нотод итгэнэ.*

НОТОЛГОО батлагаа, нутлагаа; *нотолгоо сайтай; нотолгоо муутай.*

НОХ онох.

НОХИЛОХ эмэгтэйчүүдийн **аятай** янзтай явах; *тэр хүүхний нохилон нохилж яваагий нь харахад үнэхээр бахдалтай!* **нахилах нохилох** хорш..

НОХИОТОХ сүлбээлдэх, хуйвалдах, **нохцөн** нөхөрлөх; *чи түүнтэй их нохиотохын хэрэггүй, аягүй бол нөлөө нь халдана.*

НОХИТОХ нүүр нүд хиртэх.

НОХОЙ 1. хөхөөр тэжээгч араатны тусгай аймагт багтах тэжээвэр амьтан; *хотны нохой; өлөгчин нохой; нохойн гөлөг; нохойн байр;* **гөрөөч нохой** (анч нохой); **хоточ нохой** (хотоо манах сэргийлэхдээ үнэхээр сайн нохой); **анч нохой** (ан амьтанг барихдаа сурамгай, гөрөөч нохой); **золбин нохой** (эзэнгүй нохой): **нохой тавих** (а. ан амьтан бариулахаар нохой тухирч явуулах; б. хулгайчийг илрүүлэн олохоор хайгуулч нохойг явуулах); **нохой тухирах** (нохойг ямар нэгэн зүйлд зориуд чиглүүлэн тавих); 2. шилжсэн зальтай, мэхтэй, муу санаатай, хэцүү, төвөгтэй; **нохой хүн** (заль мэх ихтэй); **нохой явдал болох** (бэрхшээлтэй үйл явдал тохиолдох); **нохой хэрэг** (хэцүү хэрэг); **нохой зан** (муу зан); 3. сарны зурхайн арван нэг дахь жил, цаг; нохой жил; ☆ **нохой нүцгэн** (огт юу ч үгүй хоосон нүцгэн; **гахай явган, нохой нүцгэн** хорш.); **нохой гахайдаа хүрэх** (хөёр хүн хоорондоо эвдрэлдэж муу муухайгаа дуудалцах); **нохойн дуу ойртох** (ямар нэгэн үйл явдал дуусах, төгсөхдөө маш ойр болох); **нохойн толгойг ширээ дээр тавивч шороо дээр** (муу юмыг дээш татавч доошоо); **нохойн гэдсэнд шар тос тогтохгүй** (муу юманд сайн юм үл тохирох); **нохой хамартаа тулбал усч** (амин дээрээ тулахаар аргы нь олдог); **нохой хараацай** амьтан (хөгц бялзуухай); **нохой мич** амьтан (мичний нэгэн зүйл); **нохойн ялаа** амьтан (нохойн биед төрсөн ялаа); **нохой галуу** амьтан (халуу мэргэн гэдэг шувууны улаан хушуутай алаг хүзүүтэй нь); **нохой шогшор** амьтан (нүд улаан, жигүүр урт, модны батганыг барьж иддэг нэгэн зүйл шувуу); **нохой өтөг** амьтан (өвөл модны хонгилд орших бяцхан өтөг); **нохой бөөс** амьтан (цус сорогч үсэрдэг жижигхэн хорхой); **нохой далан хальс** ургамал (голын ойр ургадаг, алаг дүрстэй ,цайвар улаавтархан өнгийн цэцэгтэй нэгэн зүйлийн модорхог ургамал); **нохой хуш ургамал** (богино болоод салаа үлэмж, самар ургахгүй хуш мод); **нохойн хуух ургамал** (зэллэж ургадаг, бяцхан гуатай төстэй, түүхийдээ ногоон, боловсроходоо хурц улаан өнгөтэй бөгөөд зөөлөн хүүрэг нэгэн зүйл ургамал); **нохойн хушуу ургамал** (голын эрэг, ойн захаар ургадаг бутархаг ургамал, мөчир ба ишиндээ өргөстэй, том ягаан цэцэгтэй, үр жимс нь витамин ихтэй, чийг бамын өвчинд хэрэглэнэ); **нохой зангуу ургамал** (тарианы газар, замын хажуу газраар ургадаг, үр нь тостой бөгөөд түүгээр маажин хийнэ, навч ба үндэс нь шар, ногоон будагтай, зангуу нь малын арьс үсэнд шигдэнэ): **нохойн шээрэн ургамал** (нохойн шийрийн нэг зүйл ургамал); **нохойн хэл ургамал** (уруул цэцгийн язгуурын олон наст ургамал, ягаавтар цэцэгтэй); **нохойн шийр ургамал** (говь цөл газар ургадаг сөөг ургамал, шүүслэг гонзгой навчтай, навчийг мал амтархаж иднэ); **нохойн хоншоор ургамал** (зэрлэг тэргүүлэгч цэцэг); **Тэнгэрийн гурван нохой** зурхай (гурван марал).

НОХОЙДОХ хэтэрхий нохой зан гаргах.

НОХОЙМСОГ нохойрхуу.

НОХОЙРОГ нохойрхог.

НОХОЙРХОГ нохойрхуу.

НОХОЙРХОХ нохой зан гаргах, нохойтох.

НОХОЙРХУУ яриа зальтай, мэхтэй, муу санаатай, хэцүү; *нохойрхуу хүн.*

НОХОЙТОХ заль мэх гаргах, нохой зан гаргах.

НОХОЙТУУЛАХ нохойтохын үйлдүүлэх хэв, нохойгий нь хөдөлгөх.

НОХОЙЧ 1. нохой зантай; 2. нохой малладаг.

НОХОЙЧЛОХ 1. довтлох, хойноос нь дагаж **элдэх**; 2. **усанд самрахад** дөрвөн мөчөөр ээлжлэн сэлэх; *нохойчилж сэлэх;* 3. нохой зан гаргах.

НОЦ оноц, онч, онцгой, сүрхий, хор холбогдол; *үгний ноц; хэргийн ноц.*

НОЦГОНО ургамал дүгрэг навчтай, чавганы цөмтэй адилхан үртэй сондуутай нэгэн зүйл ургамал.

НОЦГҮЙ үйл хэргийн холбогдол бага хөнгөн буюу хоргүй.

НОЦЛОХ 1. адгуусан араатны амаар зуулхийлэх, **байн байн** зуух; 2. гараар барилхилах, **байн байн** барих, татах; 3. юмыг гэнэт угз таган таслах, тастатах.

НОЦОГДОХ ноцохын үйлдэгдэх хэв; 1. гарт дайран баригдах; 2. оргосон зайлсан юм тохиолдон баригдах; 3. ш и л ж с э н хэрэгт хөндлөнгөөс холбогдох; *хилс хэрэгт ноцогдох;* 4. зуугдах, хазагдах; *нохойд ноцогдох.*

НОЦОЛГОНО а м ь т а н чичилганатай адил болоод нохойн хуцах мэт дуутай нэгэн зүйл амьтан.

НОЦОЛДООЧ 1. ноцолдохдоо сурамгай; 2. барилдаач.

НОЦОЛДОХ ноцохын үйлдэлдэх хэв, 1. бие биеийг барин дийлэх дийлдэхийг чармайн үзэлцэх; *хэрэлдэн ноцолдох;* 2. ноололдох; **ноцолдох ноололдох** х о р ш.; *хүүхэд тоглоя ноцолдох;* 3. оролдох, удаан хийж ядах; *цагаар ноцолдох; ажлаар ноцолдох; хонь малаар ноцолдох.*

НОЦОЛДУУЛАХ ноцолдохын үйлдүүлэх хэв, ноцолдоход хүргүүлэх.

НОЦООЛГО 1. ноцоодог юм; миний *ноцоолгын бензин дууссан байна;* 2. гэрэл чийдэнг асаах хэрэгсэл; *чийдэнгийн ноцоолго.*

НОЦООЛГОХ ноцоохын үйлдүүлэх хэв.

НОЦООХ асаах, шатаах; *шүдэнз ноцоож тамхи татав; гал ноцоох.*

НОЦОХ I асах, шатах; *гэрэл ноцох; гал ноцох.*

НОЦОХ II 1. юмыг гараар сочмог барих; *би эмнэг даага ноцон барив;* 2. ямар нэгэн үйл хэрэгт бусдыг уршиглан татах; *хулгайн хэрэгт ноцох; эсэргүү хэрэгт ноцох; худал үгээр гүтгэн ноцох;* 3. зуух, хазах; *чоно нохой ноцох*

НОЦТОЙ оноцтой, ончтой, сүрхий, онцгой шинжтэй; *ноцтой дутагдал; ноцтой хэрэг; ноцтой шалтгаан.*

НОЦУУЛАХ 1. ноцохын үйлдүүлэх хэв; 2. ноцогдох.

НӨГӨӨ 1. хоёрдугаар, бусад, өөр; *нөгөө талд нь бичсэн байв; нэг нь залуу, нөгөө нь хөгшин;* 2. өнөөх; *нөгөө юмаа аль; нөгөө хүн чинь энэ; нөгөө ярьдгийгаа авчирсан уу?*

НӨГӨӨДӨР маргаашийн дараах өдөр; *нөгөөдөр гуравдугаар сар гарна.*

НӨГӨӨДҮҮЛ бусад хүмүүс; *нөгөөдүүл чинь ирсэн үү? нөгөөдүүлээс чинь захидал байна уу?*

НӨГӨӨЛӨХ бусдыг мууд унагаахаар оролдон явах.

НӨГӨӨТӨХ өнөөх, өөр бусад юм; *нөгөөдөхөө дууд! нөгөөдөхий нь үзье; нөгөөдөх чинь хаа байна?*

НӨГӨӨТЭЭГҮҮР нөгөө талаар, үүний гадна, бас; *үүний нөгөөтээгүүр; нөгөөтээгүүр зохих газар мэдэгдэн дагаж шийтгүүлсүгэй.*

НӨГӨӨХ 1. өөр, бусад, нөгөөдөх; 2. мөнөөх, өнөөх.

НӨГЧИХ 1. өнгөрөх; *цаг нөгчих тутам;* 2. удаашрах, улирах, саатах; 3. ш и л ж с э н үхэх; *нас нөгчив.*

НӨГЧӨӨХ нөгчихийн үйлдүүлэх хэв; 1. өнгөрүүлэх; 2. улируулах, саатуулах, удаашруулах; 3. ш и л ж с э н үхүүлэх.

НӨЖ бүрэлдсэн цус; цус нөж х о р ш.; *бөөн бөөн нөж гарав.*

НӨЖЛӨХ нөж болгох.

НӨЖРӨӨХ нөж болгох, нөжрүүлэх.

НӨЖРӨХ 1. цус бүрэлдэж өтгөрөн бөөгнөрөх, нөж болох; 2. цохигдох буюу нухагдахад арьсан дотор цус хурж хөхрөх.

НӨЖРҮҮЛЭХ нөжрөхийн үйлдүүлэх хэв.

НӨЛ галын дөл.

НӨЛДӨХ дөлөөр халаах.

НӨЛӨӨ I 1. гараг өвчин, саа; *нөлөө дайрах;* 2. толинд гажуу дүрс гарах; *нөлөөтэй толь.*

НӨЛӨӨ (Н) II ямар нэгэн өтгээдийн нөгөөд үзүүлэх чадал, хүчдэл, уршиг, шалтгаан; *нөлөө үзүүлэх; нөлөөнд автагдах; нөлөө ихтэй; хувьсгалын нөлөө.*

НӨЛӨӨ III галын илч.

НӨЛӨӨГҮЙ уршиг хоргүй, халгүй.

НӨЛӨӨДӨХ нөлөө нь хүрэх, халдах.

НӨЛӨӨЛӨГДӨХ нөлөөлөхийн үйлдэгдэх хэв.

НӨЛӨӨЛӨЛ нөлөөлөх үйлийн нэр.

НӨЛӨӨЛӨХ юмны нөлөө хүрэх, халдах; *сайн талаар нөлөөлөх; муугаар нөлөөлж байв.*

НӨЛӨӨЛҮҮЛЭХ 1. нөлөөлөхийн үйлдүүлэх хэв, 2. нөлөөлөгдөх.

НӨЛӨӨТӨХ 1. нөлөө өвчин гусах; 2. нөлөө халдах.

НӨЛӨӨТЭЙ нөлөө их, хор уршиг ихтэй, халтай; *нөлөөтэй хүн.*

НӨЛӨХ ус салхинаа элс шороо хоролзох, эргэлдэх.

НӨЛТӨХ галын нөл гарч шатах.

НӨМИЙЛГӨХ нөмийхийн үйлдүүлэх хэв.

НӨМИЙХ мод зэргийг овоолон цогцлоход сагсайн тулалцах.

НӨМӨР 1. салхи жавар халхалсан юм; *нөмөр газар; пингийн нөмөрт; энгэр өвөр газар нөмөртэй байдаг; нөмөр барих;* 2. бусдын нөлөө асрамж; *сайн юмны нөмөрт халхлагдаж яваа хүн байгаа юм.*

НӨМӨРДӨХ 1. нөмөрт хоргодож байх; 2. хэтэрхий нөмөр болох.

НӨМӨРДҮҮ нилээд нөмөртэй.

НӨМӨРДҮҮЛЭХ нөмөрдөхийн үйлдүүлэх хэв.

НӨМӨРЛӨХ нөмрөөр халхлах, нөмөр хийх.

НӨМӨРЛҮҮЛЭХ нөмөрлөхийн үйлдүүлэх хэв.

НӨМРӨГ 1. хатдын дээлийнхээ гадуур нөмрөх гоёлын хувцас; 2. бүсгүйгээр гадуур нөмрөх давхац, цув.

НӨМРӨГЛӨХ нөмрөх.

НӨМРӨХ 1. дээгүүр хучиж тавих; *дээлээ нөмрөн гарч ирэв ;хөнжлөө нөмрөн хэвтэв; өнгөрсөн бороонд цув нөмрөх* з ү й р; 2. ш и л ж с э н давж халин орж ирэх; *үерийн ус нөмрөн авлаа.*

НӨӨЛГӨХ нөөхийн үйлдүүлэх хэв, нөөхөд хүргүүлэх.

НӨӨЛӨГ 1. уулыг өнгөрөн ирж, нөмөр газарт хорголзож үйлээн дэлдэх салхи; *нөөлөгтэй ам; нөөлөгтэй газар;* 2. зуухны утаа яндангаар гарахгүй салхинд давтагдан эгж хоргох.

НӨӨЛӨГЛӨХ нөөлөг салхи дайрах.

НӨӨЛӨХ уул давж ороон ирсэн салхины дороос дээш сөхөн салхилах.

НӨӨХ нөөцлөх, дараа хэрэглэхээр хойш тавьж хадгалах; *наадамд явах гэж бас их нөөж байгаа даа.*

НӨӨЦ 1. бэлтгэл; **нөөц бэлтгэл** х о р ш.; *нүүрсний нөөц; нөөц баялаг;* 2. хайрлан хадгалж үлдээсэн юм, *нөөц ихтэй аж ахуй; өвлийн нөөц.*

НӨӨЦЛӨХ нөөц болгон хадгалах; *мах сүү ногоо зэрэг идэш уушийн зүйлийг нөөцөлжээ.*

НӨӨЦЛҮҮЛЭХ нөөцлөхийн үйлдүүлэх хэв.

НӨР (ӨН) 1. авд салахгүй, авд зогсохгүй, ужиг; *нөр өвчин; нөрөн орох; нөрөн ярих;* 2. авд мохохгүй, авд цуцаж зогсохгүй, дөжир; 3. зөрүүд, зүтгээ.

НӨРЛӨХ нөр ажиллах, авд цуцаж зогсохгүй үйлдэх; *нөрлөн байлдах.*

НӨРӨӨ I нөрөх сүрхий, хэтэрхий зөрүүд.

НӨРӨӨ II цэцэг өвчнөөс нүүрт тогтсон сорви.

НӨРӨӨТЭЙ нөрөө сорви ихтэй; *нүүртээ нөрөөтэй.*

НӨРӨХ I 1. **нөр зан** гаргах; 2. гөжүүдлэх.

НӨРӨХ II муруйх хазайх, далих, нөрүү болох.

НӨРҮҮ муруй, хазгай, далиу.

НӨХВӨР дэмжиг, нэмүүр; **нэмүүр нөхвөр** х о р ш.; *эд юмаар нөхвөр болох; биеэр нөхвөр болох.*

НӨХВӨРЛӨХ нэмэр нөхвөр болох, болгох.

НӨХӨД олон нөхөр, нөхрийн олон тоо; *манай нөхөд гүйцэн ирэв; хайрт нөхөд өө! нөхөд* сэлтийн *хамтаар;* **нөхөд сэлт** (хань дагалт).

НӨХӨДТЭЙ нөхөр олонтой, нөхөрсөг зантай.

НӨХӨӨС 1. нөхөж битүүлэн тавих зүйл; *нөхөөс тавих; дээлийн нөхөөс; төмөр шанагад нөхөөс тавьж байв;* **далан нөхөөс** (энд тэндгүй уранхай цоорхой); 2. х у у ч и р с а н шарх; **шарх нөхөөс** х о р ш.: 3. ш и л ж с э н нэмэр; **нэмэр нөхөөс** х о р ш.; 4. оронд, төлөөсөнд; *ажилд явахгүй, хүний нөхөөсөнд би явах гэж үү?*

НӨХӨӨСЛӨХ 1. нөхөх, нөхөөс тавих, нөхөөс болох; 2. **х у у ч и р с а н** байлдаанд шархтах.

НӨХӨР 1. дотно хүн, үзэл санаа, үйл ажил, аж амьдрал зэргээр ойрхны хүн; *нөхрийн хувцаар чамд хэлэх хэдэн үг байна; анд нөхөр;*

найз нөхөр; хэн нь нөхөр, хэн нь дайсан болохыг ялгаж таних; зовох цагт нөхрийн чанар танигдах; нөхрийг нөхрөөр нь шинж х у у ч; *нөхрөө үзэж сур! сүүдрээ үзэж зас!* х у у ч.; **нөхөр татах** (хэргийн учир байцаагдаж мөрдөгдөхөд бусдыг гэмт хэрэг хийлцсэн гэж нотлох, хань хамсаа болгох; *хулгайд нөхөр татах);* 2. эхнэрийн эр; *нөхөр нь Батчулуун гэгч хүн; манай нөхөр үйлдвэрт ажил хийдэг;* **нөхөр хань** х о р ш.; 3. өөрийн нийгэм, өөрийн орчны хүн; *нөхөр Сүхбаатарын хамт; нөхөр Уртнасанг сонгов;* **нөхрийн шүүх** (ялимгүй осол эндэгдлийг нөхрийн ёсоор олноороо зөвлөн хэлэлцэж **засах** олон нийтийн байгууллага).

НӨХӨРЛӨГ хүнтэй эе эвтэй хүн, нөхөрсөг.

НӨХӨРЛӨЛ нөхөрлөх үйлийн нэр; **сэхээтний нөхөрлөл** (социалист хөдөлмөрийн төлөө бригадад туслах сэхээтний эвлэл).

НӨХӨРЛӨХ нөхөр найз бололцох, найзлах; *олон жил нөхөрлөв; хүний ясыг нөхөрлөж таних.*

НӨХӨРЛҮҮЛЭХ нөхөрлөхийн үйлдүүлэх хэв.

НӨХӨРСӨГ нөхрийн чанар сайтай, нөхөрлөг *манай хоёр орны нөхөрсөг харилцаа жилээс жилд сайжирсаар байна.*

НӨХӨРТЭЙ 1. найз олонтой; 2. эр нөхөртэй.

НӨХӨХ 1. нөхөөс тавих; *гэрийн цоорхойг нөхөх;* 2. ш и л ж с э н орлох; *дутуу орон тоог нөхөв; нөхөн гүйцэтгэх; нөхөн төлөх;* **алба нөхөх** х у у ч и р с а н (бусдын төлөө алба залгуулах).

НӨХҮҮЛЭХ нөхөхийн үйлдүүлэх хэв.

НӨХЦӨЛ 1. шалтгаан, нөлөө; **нөхцөл шалтгаан** х о р ш.; *бүтэх нөхцөлтэй хэрэг;* 2. ахуй боломж, ахуй байдал; *орон нутгийн нөхцөл байдалд тохируулан...;* 3. үгийн хүртээл дагавар; *нөхцөл залгах, нөхцөл үг;* **нөхцөл үйл үг** (үйл үгийн нэгэн хэлбэр).

НӨХЦӨЛГҮЙ 1. нөхцөл байхгүй, болохгүй, бүтэхгүй 2. ямар ч арга бололцоо байхгүй; *тэр ч харин бүтэх нөхцөлгүй хэрэг.*

НӨХЦӨЛДӨХ нөхцөхийн үйлдэлдэх хэв, харилцан нөхцөх.

НӨХЦӨЛДҮҮЛЭХ нөхцөлдөхийн үйлдүүлэх хэв.

НӨХЦӨЛТЭЙ боломжтой, аргатай, найдвартай; *бид төлөвлөгөөгөө биелүүлэх нөхцөлтэй байна.*

НӨХЦӨӨХ 1. нөхцөхөд хүрүүлэх, нөхцүүлэх; 2. өнгөрүүлэх; *цаг нөхцөөх.*

НӨХЦӨХ 1. ханилах, нөхөр бололцох, нөхөрлөх; *ханилж нөхцөх;* 2. ш и л ж с э н тохиох, зууралдах, санаашрах, хүслэн болох; *айл хэсэхийн дон нөхцөх; хөзөр тоглохын дон нөхцөжээ;* нас **нөхцөх** (нас барах, үхэх).

НӨХЦҮҮЛЭХ нөхцөхийн үйлдүүлэх хэв, нөхцөөх.

НУГА I 1. хээр буюу голын дагуу байх чийг ихээхэнтэй ургац сайтай хэсэг газар; *голын нуга; нуга дагуулж малаа билчээ!* 2. товгорхон хэсэг буюу нуруу мэт газар; **уул нуга, нуруу нуга** х о р ш.

НУГА II хүч нэмэгдүүлэх сул үг; *нуга дарах; нуга татах; гэдрэг нь нуга дарав.*

НУГАЛАА 1. нугалсан газар, нугалахад тогтсон ором; **нугалаа гарах** (нугалсан оромтой болох); 2. ш и л ж с э н юмыг биелүүлэх, бүтээхдээ хэтрүүлэн хор хөнөөл болоход хүргэх; **зүүний нугалаа** (онол буюу практик ажилд зүүний хэтрүүллээр хор хөнөөл болгох).

НУГАЛААС нугалагдсан газар; *олон нугалаас гарчээ. нугалаасы нь гартал илүүрд!*

НУГАЛААТАН хэтрүүлэгчид; *зүүний нугалаатан.*

НУГАЛАМ нуруу сээрний нугалсан нэг үе; *нэг нугалам харцага.*

НУГАЛАХ 1. эвхэж нугалаас гаргах; *цаасыг дундуур нь нугалах; номыг нугалж болохгүй;* 2. тахийлган матриулах; *хадаасны үзүүрийг нугалах; шилийг нугалж болохгүй;* 3. ясыг үеэр нь огтлон салгах; *нурууны үе нугалах; хүзүү нугалах;* 4. ш и л ж с э н хувь өсгөж нэмэгдүүлэн авах; *нугалан торгох; нэг хувиар нугалах;* 5. нугалаа гаргах; *нугалаа гаргаж улс төрийн алдаа хийх.*

НУГАЛБАР 1. нугалбарласан юм; *нугалбар цаас;* 2. х у у ч и р с а н цаас нугалан бичсэн айлтгал бичиг; *уул нугалбарт улаан бийраар цохов.*

НУГАЛБАРЛАХ эвхэж нугалан давхарлах; *даавуу нугалбарлах; цаас нугалбарлах.*

НУГАЛРАХ нугалаас гарах, нугархай болох.

НУГАЛУУР зарим амьтны ходоодны нарийн үзүүрийн зузаан хэсэг, гүүний хэрчим; ходоодны нугалуур; *нугалуур идвэл нутаг сахидаг* х у у ч .

НУГАЛХИЙЛАХ нугалах, нугалаа гаргах.

НУГАН хөвгүүн, нуган хөвгүүн х о р ш . .

НУГАРААЧ биеийн тамирын нугарах эрдэм үзүүлэгч; *уран нугараач.*

НУГАРАЛ нугарах үйлийн нэр.

НУГАРАЛТ нугарал, нугарах явц.

НУГАРАХ 1. нугалаас гарах, нугалаастай болох; *хормой нугарах; зах чинь нугарчээ;* 2. үе, нугастай юм атрих; *өвдөг нугарах; гэдрэг нугарах;* 3. ш и л ж с э н буурах, намжих; *хүйтний ид нугарах; өвчний байдал нугарчээ; миний ажил нугарч байна.*

НУГАРУУЛАХ нугарахын үйлдүүлэх хэв.

НУГАРХАЙ юмны нугарч ором тогтсон газар.

НУГАС I а м ь т а н өргөн хушуутай, богино хүзүүтэй, богино бөгөөд сарвагар сарвуу бүхий хөлтэй, усанд хөвдөг шувуу; *нугас дууриаж элээ усанд унах* з ү й р.

НУГАС II нурууны үеийн нүхэн дотор байх мэдрэлийн системийн бодис; *тархи нугас;* **нугасны ус** (нугас орших сувагт байх шингэн зүйл).

НУГАС III 1. механизмын хоёр ангийн гол бүхий хөдөлгөөтэй холбоо; 2. хаалга, хавхаг мэтэд хадах, эргэх голтой хоёр хэсэг хавтгай; төмөрлөг; *хаалганы нугас;* 3. нийлүүлэх хоёр банзны хооронд зууж тээг болгох бяцхан мод.

НУГАСЛАГДАХ нугаслахын үйлдэгдэх хэв.

НУГАСЛАХ 1. амьтныг алахаар нугасыг хатгах, таслах; *нугаслан алах;* 2. ш и л ж с э н мод хөрөөдөн огтлоход ихэнх талыг хөрөөдсөний дараа нөгөө талаас хөрөөдөн тастатах; *хөрөөдсөн модоо нугаслав;* 3. ш и л ж с э н юмыг зөрүүлэхгүйгээр нэгийг нүхлэж нөгөөг шургуулах буюу хоёулыг нөхөлж завсарт өөр юмаар хэлхэн залгах; 4. юманд нугас суулган хийх, нугастай болгох.

НУГАСЛУУЛАХ 1. нугаслахын үйлдүүлэх хэв; 2. нугаслагдах.

НУГАСХИЙХ нэгэнт нугалах, нугалан давхарлах; *хөлөө нугасхийн сөхрөв; барьж явсан ширдгийг нугасхийж тавиад дээр нь суув.*

НУГАЦ биенйг далдлан нуух газар; **нугац суух** (нугацад бие далдлах).

НУГАЧИХ 1. байн байн, дахин дахин нугалах; *сээрний ясыг нугачиж орхив;* 2. гэнэт нэгэн удаа нугарах; *хөлөө нугачин сууж орхилоо.*

НУГАЧУУЛАХ нугачихын үйлдүүлэх хэв.

НУГДАГА: нугдага нугдага хийх нугдгар юмны үргэлжлэн хөдлөх байдал.

НУГДАЙЛГАХ нугдайхын үйлдүүлэх хэв, нугдгар болгох.

НУГДАЙХ нугдгар болох.

НУГДАЛЗАХ нугдгар юмны нугдас нугдас хөдлөх.

НУГДГАЛЗАХ нугдалзах.

НУГДГАНАХ нугдгар юмны нугдага нугдага хөдлөх.

НУГДГАР хүзүү богино, бие атигар; *нугдгар хүзүүт.*

НУД: нуд хийх үе гишүүний чадхийж дуугарах; *хуруу нуд хийх; хүзүү нуд хийх.*

НУДАРГАН зарц, ядуусыг дарлан мөлжих баян, баялаг этгээд; *нударган баянтай тэмцэх.*

НУДАРГАНЧУУД нударган баячууд.

НУДРАГА 1. зангидсан гар; **нудрага зангидах** (гарын таван хуруур чанга атгах); 2. ш и л ж с э н чадамгай, дадлага; *нудрага суух; нудрагатай зураач болжээ;* 3. дээлийн ханцуйны үзүүрт хийх туурай; *нудрагатай дээл.*

НУДРАГАДАХ 1. нудрагаар гүйцэтгэх; *хашраараа нудрагадаж байна;* 2. нударгалах; 3. хүч чинээгээр бардам дийлэх; *чадлаараа нудрагадах нь зөв.*

НУДРАГАЛАГДАХ нудрагалахын үйлдэгдэх хэв.

НУДАРГАЛАХ 1. зангидсан гараар жанчих, дэлдэх; 2. бусдыг мундагдан аашлах, юмыг хүчээр тулгах.

НУДРАГАЛУУЛАХ 1. нудрагалахын үйлдүүлэх хэв; 2. нудрагалагдах.

НУДРАГАШИХ нудрага суух, чадамгай болох; *ажилд нудрагаших.*

НУДРАГДАХ нудрахын үйлдэгдэх хэв, нудруулах.

НУДРАХ 1. ёврох, огзом түлхэх; *морь хоншоороороо нудраад авчээ; гараараа нудрах;* 2. цээрлэсэн алах; *над нэг хонь нудраад өгөөч.*

НУДРУУЛАХ 1. нудрахын үйлдүүлэх хэв; 2. нудрагдах.

НУДЧАА нудрах зантай; *нудчаа хурга.*

НУДЧИХ дахин дахин нудрах; *тугал эхийгээ хөхөж байгаад нудчиж байв.*

НУДЧУУЛАХ нудчихын үйлдүүлэх хэв.

НУЖИГНАХ шажигнах, нуд хийж чимээ гарах; *хуруу нужигнах; хунгар мэт нужигнан дуугарав.*

НУЖИГНУУЛАХ нужигнахын үйлдүүлэх хэв.

НУЛГААХ юмыг шүдээр зулгаан идэх; *мах нулгаах.*

НУЛИМАХ шүлс цэр хаях; *хүний өөдөөс битгий нулим!*

НУЛИМС 1. нүдний дэргэд орших булчирхайгаас гарах тунгалаг шингэн зүйл; *нулимс асгаруулан уйлах; хонгор жаахан үр минь дээ, хоёр нүдэндээ нулимстайяа* (ардын дуу); *нулимсаа унагаахаар нудрагаа зангид* зүйр; *нүдний нулимс; нулимсны булчирхай; нулимсны сав;* 2. нулимж хаясан шүлс, цэр; **нус нулимс, нулимс шүлс** хорш..

НУЛМАЛАХ байн байн нулимах.

НУЛМАС нулимс.

НУЛМАХ нулимах.

НУЛМИДАС нулимахад гарсан цэр нулимс.

НУЛМИУЛАХ нулимахын үйлдүүлэх хэв.

НУЛМУУР нулимах сав.

НУЛТ нунж дорой; *нулт дорой хүүхэд;* **нулт нунж** хорш..

НУЛХ хуучирсан бөө нарын сүүжний тус уяж сажин дуугарах нарийн төмөр хонгио.

НУМ 1. хөвчийг татаж сум харвах зэвсэг; хулс, эвэр, шөрвөсийг нийлүүлэн нааж хийнэ, одоо спортын хэрэгсэл; *дэрсэн нум сумаа гэр дээр нь хаяв гэнэ* (үлгэрээс); *сумаа харваад нумаа нуух* зүйр; **нум орох** (нумны нэг этгээд гэдрэг нугарах); **нум буух** (**нумны хөвч** мултрах); **нум гүйтэх** (нумны хөвчийг мултлах); **нум галжиртах** (нум гажих); **нум татах** (нум барьж хөвчнөөс үгтээх); **нум тэлэх** (нумыг гүйцэд татах); **нумны амгайвч** (нумны хөвч торгох торомж); **нумны үүсгэр** (нум хийхээр бэлдсэн мод); **нумны элэг** (нуманд наасан эвэр); **нумны баатар** (нумны хайгуулын дэргэдэх дүгрэг юм); **нумны бариул** (нумны барих газар); **нумны хайгуул** (нумны хөвчийг тосох гандгар газар); **нумны хамар** (нумны хичрийн ар); **нумны хэрсүү** (нумны хайгуул); **нумны хичир** (нумны үзүүрийн гандгар); **нумны хөвчлүүр** (нумны амгайвч); **нумны галжир** (нумны гажлага); **нумны тэвх** (нумны хайгуул); **нумны товх** (нумны баатар); **нумны хөвч** (нум хөвчлөх оосор); 2. нумны хэмжээний газар; нэг *алхам* газар; *сурыг дөчин таван нумны газраас харвана;* 3. тэрэг, автомашины донсолгоог зөөлрүүлэхийн тулд хийсэн уян хатан болд; *нумтай тэрэг; машины нум; нумы нь хотойтол ачив;* 4. хэмжих ухаан хагас дугуй; ☆ **нуман жагсаал** (хавирган сар мэт хэлбэртэй жагсаал).

НУМАВЧ жижигхэн нум мэт юм; *өрөм эргүүлэх нумавч; шагаа харвах нумавч.*

НУМДАХ ноосыг сэмчин задлахаар тусгай хөвчтэй нум мэт багажаар савчиж сэмлэх; *унгас нумдах.*

НУМДУУЛАХ нумдахын үйлдүүлэх хэв.

НУМЛАХ 1. нумаар хэмжих; *газар нумлах;* 2. нум мэт тахийх; *гэдрэг нумлан толгойгоо газар хүргэв; нумлан нугарах; үүрга нумлах.*

НУМЛУУЛАХ нумлахын үйлдүүлэх хэв.

НУМЧ 1. нум хийдэг хүн; 2. унгас нумддаг хүн.

НУМЧИН олон нумч.

НУНЖ дорой буурай; *нунж хүүхэд; бие нь нунж байна.*

НУНЖГАР дорой, тэнхэл муу, унжгар уруу; *нунжгар биетэй.*

НУНЖГАРДАХ хэтэрхий нунжгар болох.

НУНЖИЙХ нунжгар болох.

НУНЖРАХ 1. нунж болох; 2. удаашрах, унжрах.

НУНТАГ няцалсан, талхалсан, нарийн үүрмэг юм; *нунтаг эм; тамхины нунтаг; нунтаг ааруул.*

НУНТАГЛАХ 1. нунтаг болгох, талхлах, няцлах; *эм нунтаглах;* 2. ш и л ж с э н дав дув, биш, назгай байх, будлих.

НУНТАГЛУУЛАХ нунтаглахын үйлдүүлэх хэв.

НУНТАГРАХ нунтаг болох; *тамхи нунтгарч орхилоо.*

НУНТАГШИХ нунтаграх, нунтаг шинжтэй болох.

НУР: нур хийх шард пард хийх чимээ гарах; *нуруу нур хийж дуугарлаа; цасан дээр дарахад нур хийв;* **нур нур хийх** (а. олон үгтэй хүнийг шоодворлон өгүүлэхэд хэрэглэнэ; *нур нур хийгээд салдаггүй амьтан;* б. байн байн нур хийх).

НУРАА эргийн өмрөн нурсан тохой газар; өрэг **нураа** х о р ш . .

НУРААХ нурахын үйлдүүлэх хэв, нурахад хүргүүлэх.

НУРАМ нурма, галтай үнс.

НУРАХ 1. бутран тарж унах, ойчих; *хураалттай түлээ нурах; байшингийн туурга нурах;* 2. төлөвлөгөөт бүтээх, үйлдвэрлэх зүйлийн төлөвлөгөө биелэхгүй тасрах; *төлөвлөгөө нурах; ажил нурах.*

НУРГИУЛАХ нургихын үйлдүүлэх хэв.

НУРГИХ 1. намуухан хүнгэнэн дуугарах; *нуурын дунд нургиад байдаг, нуруу нь алаг нугас даа* (ардын дуу); 2. ш и л ж с э н зөөлөн буцлах; *цай нургитал буцлав;* 3. борооны нарийн ширхгээр зөөлөн орох; *бороо нургин орох;* 4. зөөлөн жигд явдал; *миний хээр морь ч сайхан нургиж явна.*

НУРМА I нурам, галтай үнс; *төмсийг нурмад булан идэхээ; халуун нурма.*

НУРМА II хэрүүл цуугиан; *нурмаа тарьж байна; хэрүүлийн нурма.*

НУРАМГАНАХ нурамгар юмны нурамга нурамга хөдлөх.

НУРАМГАР царай дорой, уруу нунжгар байдалтай.

НУРАМГАРХАН баахан нурамгар, нилээд нурамгар.

НУРМАЙХ нурамгар болох.

НУРУУ 1. хүн ба зарим адгуус амьтанд ар голын дагуу байх бөгөөд дотор нь нугас орших хэсэг хэсэг олон яс, залгасан мөгөөрсөөр бүтсэн **зүйл**; *нурууны дээр нь тохох;* **нуруугаа** авах (морины нуруу эмээлд холгох); 2. хүний ар тал; ***нурууны тал; нуруу хөшөөд байна;*** **нуруугаа үүрэх** (хоёр гараа ардаа сольцон барих); *нуруугаа үүрсэн нь намайг голох, нусаа чирсний нь би голох* з ү й р ; 3. хүний өндөр нам; **дунд зэргийн нуруутай** (өндөр ч биш, нам ч биш); 4. уулын урт шил; *Хэнтийн нуруу; Уралын нуруу;* 5. орон байшин, хашааны хаалга мэтийн дээгүүрх уртааш мод; *майхны нуруу; байшингийн нуруу; нуруу мод;* б. ш и л ж с э н төлөв, гол, ерөнхий байдал; **нуруутай хүн** (төлөв томоотой, гайгүй, нилээд сайн); **дүн нуруу нь** (ерөнхий төлөв нь); 7. хураан цогцолсон юм; *таван нуруу өвс авлаа; нэг нуруу аргал овоолов; бараа таваараа нурууллаж хураасан.*

НУРУУВЧ I ерөнхий тойм, ихэнх хувь.

НУРУУВЧ II нуруугаар давхацлах нэгэн зүйл хувцас.

НУРУУВЧЛАХ I үйл ажлын ихэнхийг дуусгах, бараглах; *ажлаа нурууувчилж орхилоо.*

НУРУУВЧЛАХ II нуруувч хувцсаа өмсөх.

НУРУУВЧЛУУЛАХ нуруувчлахын үйлдүүлэх хэв.

НУРУУГҮЙ 1. нуруу байхгүй; *нурууггүй хүний үлгэр;* 2. нуруу муутай; *нурууггүй морь;* 3. төлөвгүй, үнэнч биш.

НУРУУЛАХ I нуруу газраар дамжин явах.

НУРУУЛАХ II нурууллах.

НУРУУЛДАХ юмыг нуруу болгож хураах; *өвс нурууллах; мод нурууллах; гурил нурууллах.*

НУРУУЛДУУЛАХ нурууллахын үйлдүүлэх хэв.

НУРУУЦАХ ихэнхийг хийж дуусах, ихэвчлэн гүйцэтгэх; *ажлаа нурууцаж байна.*

НУРШАА үглээ, олон үгтэй, яншаа; *нуршаа хүний аюул шүү.*

НУРШИН 1. наалданги, лагшим юм; *нуршин цавуу; нуршин чанар* 2. шилжсэн үг яриг, улиг болсон, илүү үгтэй; *нуршин хүн;* 3. х у у ч и р с а н халдамхай зантай.

НУРШИХ 1. олон үг улиглан давтан ярих; *олон үг нурших хэрэг юун;* 2. х у у ч и р с а н бусдад халдах.

НУРШЛАХ байн байн нуршин үг ярих.

НУРШУУ баахан нуршаа.

НУРШУУДАХ хэтэрхий нуршин болох.

НУРШУУЛАХ нуршихын үйлдүүлэх хэв, нуршихад хүргүүлэх.

НУС хамрын дотроос гарах салс **налдаа**; *нус гоожих; нус хатах; нусны алчуур;* **нус нулимс болох** ухилах;

НУСАРХАГ нус ихтэй.

НУСАРХУУ баахан нусархаг.

НУСГАЙ 1. нус нь гоожимтгой; 2. томуу; *нусгай хүрэх; нусгай ханиад хүрэх нь ховор.*

НУСТАЙ нусгай, нус нь гоожимхой.

НУСТАХ 1. нус их болох; 2 .нусгай ханиад хүрэх.

НУСХАЙ нусгай.

НУТ бат; нот; **бат нут** х о р ш . . .

НУТАГ 1. оршин суух газар орон; *төрсөн нутаг; манай нутагт ой мод их; нутгийн хүн; нутгийн цагаар; орон нутгийн чанартай явдал; нутаг усыг асуух; улсын нутаг дэвсгэр; аймгийн нутаг; сумын нутаг;* **нутаг дэвсгэр, орон нутаг** х о р ш.; **нутгийн аялга** (тухайн орон газрын хүн ардын ярианы аялга); **нутгийн судлал** (тухайн орон газрын түүх, газар зүй, ашигт малтмал зэргийг судлах судлал); **нутгийн захиргаа** (тухайн орон газрын захиргаа; *нутгийн захиргааг шинэчлэх);* **нутгийн ард иргэд** (тухайн газар оронд байнга оршин суугч хүмүүс); **нэг нутгийн хүн** (нэгэн газар өсч төрсөн хүн; *манай аавтай нэг нутгийн хүн юм гэнэ билээ);* **нутаг нутгийн хүн** (газар газрын хүн); 2. нутаглаж байгаа газар; *нутаг хаана вэ? нутаг зүүн голд; нутаг сонгох; нутаг сэлэх;* **нутаг билчээр, нутаг ус** х о р ш.; 3. орон гэрийн нүүсэн буйр; *туулай, айлын нутаг дээрээс ганц улаан чавга олж гэнэ* (үлгэрээс); *нутаг дээр орхигдох; аянчны нутаг.*

НУТАГЖИХ 1. орших нутагтай болох, нутаг нь их болох; 2. нутагших.

НУТАГЛАХ 1. нутагт оршин суух; *танайхан хаагуур нутаглаж байна? хэзээнээс нааш нутаглаж идээшсэн газар* 2. х у у ч и р с а н билчээр халан, давшин явах, оторлох.

НУТАГЛУУЛАХ 1. нутаглахын үйлдүүлэх хэв; 2. хүүр оршуулах, хүүр гээх.

НУТАГШИХ нутаглан идээших, дасах; *малай мал сүрэг одоо л нутагшиж байна.*

НУТАД батад, нотод; *нутад баримтлах; нутад итгэх.*

НУТЛАГАА батлагаа, нотлогоо; *нутлагаатай хэрэг; нутлагаа бий.*

НУТЛАГДАХ нутлахын үйлдэгдэх хэв, нотлогдох.

НУТЛАЛ нутлах үйлийн нэр, нутлагаа, нотлол, нотлогоо.

НУТЛАХ батлах, гэрчлэх, нотлох; *би чамайг нуталж чадна.*

НУТЛУУЛАХ нутлахын үйлдүүлэх хэв, нотлуулах.

НУУГДАХ нуухын үйлдэгдэх хэв, далдлагдах; *нуугдаж тоглох; нуугдаж хоцрох.*

НУУГДУУЛАХ нуугдахын үйлдүүлэх хэв, нуугдахад хүргүүлэх.

НУУГИХ нуурам, зохиромжтой болох; *нуугисан сайхан тараг; нуугисан аятай явдалтай морь.*

НУУГИУЛАХ нуугихын үйлдүүлэх хэв.

НУУР байгальд тогтсон, эрэг бүхий их хэмжээний тогтмол ус; *Буйр нуур; давст нуур; нуур амар бол нугас амар* з у й р; **нуур судлал** (нуурын усны бүрэлдэхүүн, усны хэмжээ зэргийг судлах судалгаа).

НУУРАМ сайхан нийцтэй, сайн найралдсан нь; *нуурам сайхан тараг.*

НУУРАХ 1. нуурам болох, тогтуухан, дөлгөөн нийцтэй болох; *зуурсан тараг сайхан нийцтэй болж нуурах;* 2. зөөлөн буцлах; *нуурталл буцлах;* 3. тогтвортой тайван билчээрлэх; *хонь маань нуурталл билчиж явна.*

НУУРЛАХ нуур болон тогтох; *хурын ус хонхор газар нуурлах.*

НУУРМАГ I хиймэл нуур, усан хадгаламж, **цөөрөм.**

НУУРМАГ II нийцтэй найрч нуурам болсон юм.

НУУХ I нүд өвчлөхөд гарах цөв идээр; *нуухыг нь авах гээд нүдий нь сохлох* з у й р.

НУУХ II юмны шигтгээг тогтоохоор тойруулан хийсэн хүрээ; *шүрэн толгойтой алтан нуухтай манан хөөрөг.*

НУУХ III бусдад мэдэгдэхгүй байх, далдлах, дарах; *нуун далдлах; хүнээс нуух; муу нуухаар сайн илчил* з у й р; *нуувч нүүрнээс*

нь илхэн, далдлавч далнаас нь илхэн з ү й р.

НУУХТАХ нүдэнд нуух тогтох; *нүд нуухтах.*

НУУХТУУЛАХ нуухтахын үйлдүүлэх хэв.

НУУЦ 1. олонд задруулахгүй, үзүүлэхгүй далдалбал зохих юм; *нууц үг; нууц хэрэг; нууц эд;* 2. хүний биеэ далдлах газар; *нууцад сууж агнах;* **нууцын эрхлэгч** (нууц албан хэргийг эрхлэх тушаал бүхий хүн); **нууц нэр** (жинхэнэ нэрээ нууж оронд нь хэрэглэх өөр нэр); **нууц үг** (ил бус байгууллага, цэргийн албанд өөрийн хүнийг мөн гэж танихад зориулан тогтолцсон үг); **нууц байгууллага** (засаг төрөөс өөрийнхөө үйл ажиллагааг нууж явуулах байгууллага); **нууц сонгууль** (ил биш, далд сонгууль); **нууц санал өгөх** (саналаа ил биш бичгээр өгөх); **нууц эрхтэн** (бэлэг эрхтэн).

НУУЦЧИЛАХ нууцлах.

НУУЦГАЙ нууц, далд; *ууланд нууцгай суудаг байжээ; нууцгай газар.*

НУУЦЛАХ нууц болгох, нуух; *харгислалын үед нэрээ нууцалж явжээ.*

НУУЦЛУУЛАХ нууцлахын үйлдүүлэх хэв.

НУХАМШ нухаж хольж найруулан хийсэн идэш; *ээзгийн нухамш; төмсний нухамш; нухамш хийх.*

НУХАМШЛАХ нухамш хийх, нухамш болгох.

НУХАХ 1. байн байн дарж үнгэх; *гурил нухах; шавар нухах; арьс нухах; нүдээ нухах;* 2. хутгаж зууран найруулах, нарийн ширхэгтэй болгох; *вазелинтай нухсан эм; будаг нухах;* 3. дарж, тулж өвтгөх; *дэвсгэрийн дороос чулуу нухаж байв;* 4. цээрлэсэн алах.

НУХЛАГДАХ нухлахын үйлдэгдэх хэв.

НУХЛАХ үргэлжлэн нухах; *хүүхэддээ нүдээ битгий нухал гэж хэлэв.*

НУХЛУУЛАХ 1. нухлахын үйлдүүлэх хэв; 2. нухлагдах.

НУХМАЛ нухаж хийсэн, нухаж талхласан юм; *нухмал алт.*

НУХУУЛАХ 1. нухахын үйлдүүлэх хэв; 2. нухагдах.

НУХУУР нухах зэвсэг; *эмийн нухуур; тарагны нухуур.*

НУХЧИГДАХ нухчихын үйлдэгдэх хэв.

НУХЧИХ байн байн нухах.

НУХЧУУЛАХ 1. нухчихын үйлдүүлэх хэв; 2. нухчигдах.

НҮГСХИЙХ санаанд тавтай нийлэлцсэн үйл ажлыг аясдуулан ашиглах, тавлах.

НҮГЭЛ 1. шашны ёсонд тэр шашны хориг цээр бүхий зүйлсийг зөрчих нь; **нүгэл хилэнц** хорш.; *нүглээ наманчлах;* 2. шилжсэн зүйгүй буруу үйл гэм, унал; *худал хэлбэл нүгэл; хулгай хийх нүгэл;* **нүгэл хураах** (бусдыг чингээгүй атлаа чингэсэн гэж тааварлан санах); **амьдын хар нүгэл** (амьд насандаа хийж үл болох хилэнцэт үйл); **арван хар нүгэл** (биеэр үйлдэх гурав, хэлээр үйлдэх дөрөв, сэтгэлээр үйлдэх гурав).

НҮГЭЛГҮЙ үнэн цагаан, зөв шударга, үнэнийгээ хэлэхэд, үнэндээ; *над нүгэлгүй гэж би бодож байна; түүнийг нүгэлгүйдээ би л хийсэн хэрэг юм шүү.*

НҮГЭЛТ нүгэл бүхий.

НҮГЭЛТЭЙ 1. үнэн биш, гэмтэй, буруутай, хилс ташаа; *гэмтэй бол нүгэлтэй;* 2. ижил хосгүй; *нүгэлтэй хурдан морь; нүгэлтэй сайхан эд;* 3. нүгэл бүхий; *нүгэлтэй үг бүү хэл.*

НҮГЭРС суман мод.

НҮД (ЭН) 1. харааны эрхтэн ба хараа; *зүүн нүд; нүдний өвчин;* **нүдээ бүлтийлгэх** (уурлах, бачимдах); **нүд нь орой дээрээ гарах** (ихэд сандрах, айх); **нүд сайтай** (хурц хараатай); **нүдий нь хариулах** (харахгүй болохы нь отох); **нүд яргах** (нүд харж болохгүй болох); **хар нүд** (нүдний цэцгийн гаднах дугараг); **нүд аних** (а. аньсгаа хавсрах; б. нас нөгчих); **нүд муутай** (а. нүдний хараа сайнгүй; б. гярхай биш); **нүдэнд өртөхгүй** (маш жижигхэн; *нүдэнд өртөхгүй юм);* **хурц нүд** (а. нүдний хараа маш сайн; б. гярхай; в. ширүүн хөдөлгөөнтэй нүд): **нүд цавчих зуур** (нүд ирмэх зуур); **нүд ирмэх зуур** (нүдний аньсга хамхих хооронд, маш түргэн); **нүдээрээ инээх** (а. хуурамчаар инээх; б. сэртэндэх зан гаргах); **нүд дүүрэн** (аятай үзэмжтэй; *нүд дүүрэн охин);* **нүд гялбах** (гэрэлд таатай харж үл болох); **нүд бүлтрэх** (нүд сугаран гарах); **нүдний эмч** (нүдний өвчнийг анагаах эмч); **нүд далд** (нүдний өмнө биш; *нүд далд яаж ч байсан яах вэ);* **нүд имнэх** (нүдээр дохиолох); **нүд хялайтал хуурах (оргүй худал хэлж хуурах); нүдний**

булай (маш үзэмжгүй); **нүдний хуруу** (өвчин); **нүдний цагаа** (өвчин); **нүдний цэцгий** (нүдний бөөрөнхий); **нүдний хөлх** (өвчин); **нүдний хараа** (нүдний үзлэг); **нүдний үүл** (өвчин); **нүдний цагаан** (нүдний цэцгийн гадуурхи); **нүдний шил** (нүдэнд зүүх хэрэгсэл); **нүдний саравч** (нүдэнд зүүх хэрэгсэл); **нүд алдах** (олныг үзэж төөрөлдөх); **нүд тайлах** (олон юм үзэж танилцах; *юм үзэж нүд тайлсан хүн*); **нүд хорхойтой** (үзсэн юмандаа шуналтай); **нүд чичих** (тусгайлан зааж зандрах); **нүд үзүүрдэх** (тусгайлан занаж зэмлэх); **нүд улайх** (а. нүдний нальх улаан болох; б. ичгүүргүй зүтгэлэх); **нүдэнд хүйтэн** (харах үзэхэд аягүй, таатай биш юм; *харахаас нэг л нүдэнд хүйтэн санагддаг юм шүү);* **нүдэнд дулаан** (харах үзэхэд аятай, тааламжтай юм); **нүд хуурах** (а. горилсон хүссэнд ялимгүй зүйл өгсөн болж өнгөрөөх; б. үйл ажлыг дүйж дайж хийсэн болж өнгөрөөх); **нүдээ улайлгах** (а. ичгүүргүй зүтгэлэх; б. ихэд уурсах); **нүд хужирлах** (шуналтай юмаа үзэх, олон юм үзэж танилцах): **нүдний гэм** (маш ховор; *манай энд өвчтэй хүн нүдний гэм);* **нүдний цэцгий мэт хайрлах** (маш эрхэмлэн хайрлах); **нүдэндээ галтай, нүүрэндээ цогтой** (цог жавхлантай, цог заль нь бадарсан); **нүдэн балай, чихэн дүлий** (үйл явдалд хараагүй үзээгүй мэт байдал үзүүлэх, харалган дүлий мэт байх); **нүд тулах** (ойртох; *нүүр тулж танилцсангүй, нүд тулж үзсэнгүй);* **нүдтэй эд** (маш сайхан эд); **нүд булаах** (маш их дур татах); **нүд гарах** (бүрхсэн юм зарим хэсэг газар цоорох, харлах; *цас нүд гарч байна);* **нүдэнд орсон хог, шүдэнд орсон мах** (арчаагүй, шаарлагдсан); **нуухы нь авах гээд нүдий нь сохлох** (юмыг эвлүүлэн засах гэж байгаад эвдэх); **мөнгө цагаан, нүд улаан** (хэтэрхий шуналт байдал гаргах); **нүдний төмөр** (саадгийн нүдний дор хадсан гурван хэсэг төмөр); **өвдөгний нүд** (хүний тойгны орчин газар); **хэрээний нүд** у р г а м а л (иш бүдүүн, хайрслаг навчтай, цэцэг цайвар ногоон, улаан хүрэн өнгийн жимсгэнэтэй, олон наст ургамал, зарим газар үхдэлийн идээ ч гэнэ); **үхрийн нүд** у р г а м а л (ой тайга, голын дагуу шугуйгаар сөөг сөөгөөр ургадаг намхан мод, мөн түүнд ургадаг хар хүрэн өнгөтэй жимсгэнэтэй, улаалзганатай төстэй, үхрийн нүдээр ча-намал хийх буюу архи боловсруулна); **хонины нүд** у р г а м а л (дэлгэрэнгүй цэцгийн язгуур, уулын таг, энгэр өвөр газраар ургадаг дугуй цайвархан цэцэгтэй ургамал); 2. өрөө ,хэсэг; *шургуулганы нүд; цонхны нүдийг нээх; ханын нүд;* 3. хээтэй цоохор юмны толбо; *цэмбэний нүд; тогосын өдний нүд*; 4. хоёрын тооны ёгт нэр.

НҮДГҮЙ 1. сохор, харалган; 2. үзэмж чанар муу; *нүдгүй эд;* 3. гярхай биш, ташаарч харамтгай.

НҮДЛҮҮЛЭХ 1. нүдлэхийн үйлдүүлэх хэв; 2. юманд нүд хийлгэх; 3. таниулж өгөх; *үсэг нүдлүүлэх.*

НҮДЛЭГДЭХ нүдлэхийн үйлдэгдэх хэв, нүдлүүлэх.

НҮДЛЭХ 1. юмыг хармагц таних болох, андахгүй мэдэх болох; *мал нүдлэх;* **мод нүдлэх** (даалуу зэргээр наадахад модыг андахгүй болох); 2. зарим ургамлын сая цухуйж ургах; *агь нүдэлж байна;* 3. гүвдрүү яр зэрэг нэгэн газар нимгэрч цоорох, шахах; *хатиг нүдлэх;* 4. цас бага зэрэг хайлж цоохортох; *хавар болж дулааран цас нүдэлж байна;* 5. шургуулга сав зэрэгт өрөө нүд хийх.

НҮДТЭЙ 1. нүд сайтай, гярхай, танимгай, нүд бүхий; 2. чанар сайтай, аятайхан; *нүдтэй эд.*

НҮДҮҮЛЭХ 1. нүдэхийн үйлдүүлэх хэв, жанчуулах, цохиулах, дэлдүүлэх; 2. нүдэгдэх, жанчигдах, цохигдох.

НҮДҮҮР няцлах нунтаглах юмыг цохих дэлдэх зэвсэг; *цайны нүдүүр; эмийн нүдүүр.*

НҮДЭВЧ сохор хүнийг удирдан газарчилж явах хүн.

НҮДЭГДЭХ нүдэхийн үйлдэгдэх хэв.

НҮДЭХ 1. нүдүүрээр дэлдэж няцлах, нунтаглах; *цай нүдэх; эм нүдэх;* 2. ихээр зодох, жанчих.

НҮЖИГНҮҮЛЭХ нүжигнэхийн үйлдүүлэх хэв.

НҮЖИГНЭХ хүчтэй дуу чимээ гарах; *тэнгэр нүжигнэн дуугарав; нүжигнэн нижигнэн дуугарчээ.*

НҮНЖИГ 1. тослог, өөх тос их; *нүнжигтэй хоол; өөх нүнжгийн зүйл; нүнжигтэй идээ*; 2. ш и л ж с э н сайн чанар; яс; *нүнжигтэй эд;* 3. ш и л ж с э н хатуу, харамч биш зан, элбэг дэлбэг зан; *нүнжигтэй айл; нүнжигтэй хүн.*

НҮР I у р г а м а л жижигхэн хар жимсгэнэ бүхий сөөг ургамал.

НҮР: **нүр хийх, нүр нүр хийх** нүргэн дуугарах.

НҮРГЭЛЭХ **байн байн нүргэх.**

НҮРГЭХ нүр нүр хийх чимээ гарах.

НҮРГЭЭН 1. үргэлжилсэн их чимээ; *тэнгэр нүргээнтэй дуугарч байв;* 2. цуу шуугиан, үймээн; *юун их нүргээн бэ.*

НҮРГЭЭНТЭЙ цуу шуугиан ихтэй, хөл хөдөлгөөн ихтэй; *нүргээнтэй их ажил болж байна.*

НҮСГЭР нүсэр.

НҮСЭР 1. овор байдал их, хүнд чамбай; *нүсэр ачаа; нүсэр хүнд ажил;* 2. олон, их; *албан газрын нүсэр орон тоог хасах хэрэгтэй байна.*

НҮСЭРДЭХ хэтэрхий нүсэр болох, онц их дэх.

НҮҮГЭЛТҮҮЛЭХ нүүгэлтэхийн үйлдүүлэх хэв.

НҮҮГЭЛТЭХ бөөн их юм алст алгуур хөдлөх; *нүүгэлтсэн хар утаа; нүүгэлтсэн бараан юм харагдав.*

НҮҮДЛЭХ нүүдэллэх.

НҮҮДЭЛ 1. нутаг сонгож нэг газраас нөгөөд шилжин явах, суурин биш; *нүүдэл хийх; нүүдлийн мал аж ахуй;* **нүүдэл суудал** х о р ш.; 2. байр сольж сэлгэх хөдөлгөөн; *нүүдлийн жүжиг; нүүдлийн жүжигчин; нүүдлийн кино; нүүдлийн номын сан; нүүдлийн улаан булан;* 3. шатар даам зэрэг тоглоом тоглоход бод хүүг сэлгэж явуулах хөдөлгөөн; *тэмээнийхээ нүүдлийг сайн харж тулхээрэй!*

НҮҮДЭЛЛЭХ айл хунарын нүүн явах, нүүх.

НҮҮДЭЛЧИН нүүдэллэн яваа айл хүмүүс; *нүүдэлчин аймаг; нүүдэлчин айл.*

НҮҮЛ 1. уналгын бүдүүн мод; 2. хүйтэнд дулаацахаар мод их овоолон шатаасан нь; *нүүлд дулаацах; нүүл асаах.*

НҮҮЛГЭХ 1. нүүхийн үйлдүүлэх хэв, нүүхэд хүргүүлэх; *би танайхыг нүүлгэж өгье;* 2. ш и л ж с э н шидэх, чулуудах; *чулуу нүүлгэх; барьж явсан талхаараа нүүлгэж орхижээ.*

НҮҮЛСЭЛ нигүүлсэл, энэрэх сэтгэл.

НҮҮЛСЭНГҮЙ нигүүлсэнгүй.

НҮҮЛСЭХ нигүүлсэх.

НҮҮНЭ: **нүүнэ хорхой** а м ь т а н шар, бүдэг шар, улаан далавчтай, далавч дээрээ хар толботой жижиг цох, хөдөө аж ахуйн ургамал хорлогч хорхой шавьжийг барьж иддэг ашигтай шавьж болно, төрөл зүйл олон.

НҮҮР 1. хүний толгойн өмнө этгээд; **нүүр царай, гар нүүр** х о р ш.; *толинд нүүрээ харах; нүүр гараа арчих; нүүр гарын алчуур; нүүр гараа угаах;* **нүүр нүүрээ харалцах** (өөд өөдөөсөө харалцах); **нүүр улайх** (ичих); **нүүр улалзах** (ихэд ичих); **нүүр өгөх** (элдэг зан ааш гаргах, эрхлүүлэх); **нүүр шагнах** (нүүр харах, өгөх); **нүүр учрах, нүүр тулах** (дайралдах, уулзах, биеэр учрах); **нүүр хагарах** (ичих, зэвүүцэхгүй болох); **улаан нүүрээрээ уулзах** (яг тулгаран учрах); **нүүрнээс гал гарах шиг болох, нүүр хийх газаргүй болох** (маш их ичих, зовох); **нүүрэн дээр нь хэлэх** (дэргэд нь хэлэх; *би бүр улаан нүүрэн дээр нь хэлсэн);* **нүүрээ буруулах** (эгцлэн харахгүй байх); **нүүрийн буянтай хүн** (хүмүүсийн талархал татсан хүн); **нүүр сайтай** (а. нэр сайтай; б. олонтой, нөхөдтэй); **нүүр муутай** (а. нэр муутай; б. олонгүй, нөхөдгүй); **нүүр бөхтэй, зузаан нүүртэй** (ичих зовохыг мэдэхгүй); **нүүр зулчилзах** (зовних царай гаргах); **нүүр жалмайх** ичихийг мэдэхгүй байх); **таних хүний нүүр халуун** (төвөгшөөх байдал); **ичих нүүрэндээ элэг наах** (муу үйл үйлдээд огт зовохгүй байх); **нүүргүй олзноос, нүүртэй гарз дээр** (шудрага бус олзноос гарз дээр); **нүүр өгөхөд шүүр өгөх** (өр өвдөхөд, өр өөд өшиглөх); 2. ш и л ж с э н нэр хүнд; **нүүр алдах, нүүрээ барах** (нэр хүндгүй болох); **нүүр харах, нүүр тал харах** (танилаар тал тохой татах); **нэрийн хор, нүүрний хир** (алдар хүндэд хор болуузай гэж болгоомжлох санаа); 3. юмны өвөр, урд тал; *авдарны нүүр байшингийн нүүр; ширээний нүүр;* 4. ном судрын эхний гадар тал буюу доторхи хуудас; *номын нүүр дээрх усэг; тавдугаар нүүрт уз;* 5. албан бичгийн эхэнд хэвлэсэн буюу дарсан тусгай тэмдэглэл; *бичиг нүүр дарах; албан бичгийн нүүр;* 6. сар жилийн эх; *нэг жил өнгөрөөд, хоёр дахь жилийн нүүрийг үзэв; долоон сарын нүүр болов.*

НҮҮРГҮЙ 1. нүүр байхгүй; 2. ш и л ж с э н нэр хүндгүй; *тэднийд очих нүүргүй болов;* 3. ичихийг мэдэхгүй; *ичих нүүргүй амьтан; нэр нүүргүй болов.*

НҮҮРДҮҮЛЭХ нүүрдэхийн үйлдүүлэх хэв, нүүр тулган гэрчлүүлэх; гэрчтэй *нь нүүрдүүлэх.*

НҮҮРДЭХ нүүр тулж гэрчлэх, нүүр тулгах.

НҮҮРЛҮҮЛЭХ нүүрлэхийн үйлдүүлэх хэв; *захидал нүүрлүүлэх; бичиг нүүрлүүлэх.*

НҮҮРЛЭХ 1. юманд нүүр хийх; *авдар нүүрлэх;* 2. гуулах, бичиг судрын дотоод учир

агуулгыг нүүр дээр нь товчлон тэмдэглэх; 3. бичгийн нүүрийг бичиг дээр дарах; 4. ш и л ж с э н ямар нэгэн муу тохиол, байн байн тохиох, учрах; *өвчин нүүрлэх; хулгай нүүрлэх.*

НҮҮРС (ЭН) мод шатахад бий болох шатах хатуу зүйл; *зуух дотор нүүрс бий;* **нүүрс тавих** (нүүрсээр галлах); **чулуун нүүрс** (газраас малтан гаргах шимийн гаралтай шатах хатуу зүйл); **нүүрсний уурхай** (чулуун нүүрс гарах орд).

НҮҮРСЖИХ нүүрстэй болох.

НҮҮРСЖҮҮЛЭХ нүүрсжихийн үйлдүүлэх хэв.

НҮҮРСШИХ нүүрс болох, нүүрс шинжтэй болох.

НҮҮРСШҮҮЛЭХ нүүрсшихийн үйлдүүлэх хэв.

НҮҮРСЧ (ИН) 1. нүүрсний ажилчин; 2. нүүрс шатаах ажилчин; 3. нүүрс зөөх ажилчин.

НҮҮРТЭЙ нүүр бүхий, нэр сайтай, танилтай талтай; *олонд нүүртэй хүн.*

НҮҮРЧЛЭХ 1. нүүр тал харах, нэгэн этгээдийг дотночлон үзэх; 2. царайчлах, аргадах.

НҮҮРЭЛДЛЭГ нүүрэлдэх үйлийн нэр.

НҮҮРЭЛДҮҮЛЭХ нүүрэлдэхийн үйлдүүлэх хэв.

НҮҮРЭЛДЭХ нүүрдэх.

НҮҮРЭМГИЙ ичиж зовдоггүй, нүүр бөхтэй.

НҮҮХ 1. гэр барааг нэг газраас нөгөөд шилжүүлэн зөөж аваачих; *хөтөл дээгүүр айл нүүж яваа харагдав; гэрээс байшинд нүүж орох;* **үүл нүүх** (үүл агаарт хөвөн явах); 2. шингэн зүйл юманд шингэж улам баалан газар авах; *цаасан дээр асгарсан бэх нүүв; тос дуссан нь нүүж том толбо болжээ;* 3. шатар, даам, бага мэтээр наадах, бод, хүү тэргүүтнийг хөдөлгөх; *би хүүгээ нүүв.*

НҮХ (ЭН) 1. юмны сүв, цооронхой газар; *цоолсон нүх; дундаа нүхтэй зоос; хамрын нүх; чихний нүх;* **нүх сүв** х о р ш.; **нүх сүв эрэх** (арга зам хайх); 2. амьтны орогнохоор малтсан эл, гүн хонхор; *тарваганы нүх; зурамны нүх;* 3. х у у ч и р с а н есөн тооны ёгт нэр; *нүүрс барьдаг хүн нүүрээ хөөдөх нь зөв, нөхөр муутай хүн нүхэнд унах нь зөв* з ү й р; ☆ **нүхэн гэр** (газар ухаж дээрээс нь битүүлэн, хүн суух хоргодох орон); **даалууны нүх** (даалууны модонд хийсэн бага бага хонхор); **нүх шахах** (даалууны нүхийг тохируулан өрж тоглох наадам).

НҮХДҮҮЛЭХ нүхдэхийн үйлдүүлэх хэв.

НҮХДЭХ 1. нүх нийлүүлэх; 2. нүх ихтэй учир тохиромжгүй болох.

НҮХЛҮҮЛЭХ нүхлэхийн үйлдүүлэх хэв.

НҮХЛЭХ юманд нүх гаргах; *уулыг нүхлэн төмөр зам тавьжээ.*

НҮХТЭЙ юманд нүх бий болох, нүх гарах.

НҮХЭР хэрс үхрийн өөр нэр.

НҮЦГЭН 1. хувцасгүй, өмссөн юмгүй; *хөл нүцгэн; толгой нүцгэн; нүцгэн биеэр;* **нүцгэн шалдан** х о р ш.; 2 .ш и л ж с э н өмсөх хувцас байхгүй; *гахай явган, нохой нүцгэн;* 3. үсгүй, *нүцгэн амьтан; улаан нүцгэн; чармай нүцгэн;* 4. мод ургамалгүй; *нүцгэн тал; нүцгэн уул;* **нүцгэн ховол** у р г а м а л (дэлбэ, доморлог зэрэг шадар эрхтэн байхгүй модлог ургамал, тарьж ургуулж болно).

НҮЦЭГЛҮҮЛЭХ 1. нүцэглэхийн үйлдүүлэх хэв; 2. нүцэглэгдэх.

НҮЦЭГЛЭГДЭХ нүцэглэхийн үйлдэгдэх хэв.

НҮЦЭГЛЭХ 1. нүцгэн болгох; *хөл нүцэглэх; усанд орохоор хувцсаа тайлж нүцэглэв;* 2. ш и л ж с э н монгол шатраар наадахад эсэргүүцлийн нөөныг ганцаар болгох.

НҮЦЭГРҮҮЛЭХ нүцэгрэхийн үйлдүүлэх хэв.

НҮЦЭГРЭХ 1. нүцгэн болох; 2. ш и л ж с э н өмсөх хувцасгүй болох, шалдрах; 3. ш и л ж сэн монгол шатраар наадахад ганц ноёнтой хоцрох.

НЭВСГЭР навсгар, унжин санжин, хөглөрхий; *нэвсгэр дах өмссөн хүн; баавгайг анх харахад нэг л сүрхий нэвсгэр амьтан байв; нэвсгэр цас оржээ.*

НЭВСИЙЛГЭХ нэвсийхийн үйлдүүлэх хэв, нэвсийхэд хүргүүлэх.

НЭВСИЙХ нэвсгэр болох, навсайх, навсгар болох; *бороонд норсон элэг шиг нэвсийж суув; дээлээ нөмрөн галын захад нэвсийн суужээ.*

НЭВСГЭНҮҮЛЭХ нэвсгэнэхийн үйлдүүлэх хэв, навсгануулах.

НЭВСГЭНЭХ нэвсгэр юмны нэвсэг нэвсэг хөдлөх, навсганах.

НЭВСРЭХ 1. нэвсгэр болох;2. нэвшрэх.

НЭВСЭЛЗҮҮЛЭХ нэвсэлзэхийн үйлдүүлэх хэв, навсалзуулах.

НЭВСЭЛЗЭХ нэвсгэр юмны нэвсэс нэвсэс хөдлөх, навсалзах.

НЭВТ цаад талд нь гартал; **нэвт шувт** х о р ш.; *нэвт хатгах; хашаа нь нэвт гардаг хаалгатай байв; нэвт мэдэх; нэвт харах; нэвт норох.*

НЭВТГЭЛЗЭХ юмыг хоёр этгээдээс ээлжлэн нэвт хатгаж оёх; *исгий нэвтгэлзэх; нэхий арьс нэвтгэлзэх; нэвтгэлзэн оёх.*

НЭВТГЭЛЗЭЭС нэвтгэлзэж оёсон оёдол.

НЭВТЛҮҮЛЭХ 1. нэвтлэхийн үйлдүүлэх хэв; 2. нэвтлэгдэх.

НЭВТЛЭГДЭХ нэвтлэхийн үйлдэгдэх хэв.

НЭВТЛЭХ юмыг цааш этгээдэд гартал хийх үйлдэх; *шөвгөөр нэвтлэх; уулыг нэвтлэх; боров дээлийг нэвтлэхээр оров.*

НЭВТРҮҮЛЭГ нэвтрүүлэх үйлийн нэр; **суртал нэвтрүүлэг** (аливаа суртал, сургаал, номлол зэргийг дэлгэрүүлэх буюу гүнзгийрүүлэн тайлбарлах): **радио нэвтрүүлэг** (аливаа дуу хөгжим, үг яриаг радиогоор явуулах; *өглөөний нэвтрүүлэг).*

НЭВТРҮҮЛЭГЧ нэвтрүүлэг хийх үүрэг бүхий хүн; *радио нэвтрүүлэгч; суртал нэвтрүүлэгч; суртал нэвтрүүлэгчдийн семинар.*

НЭВТРҮҮЛЭХ 1. нэвтрэхийн үйлдүүлэх хэв, нэвтрэхэд хүргүүлэх 2. гадагш дотогш гаргах оруулах; *гаднаас бараа нэвтрүүлэн ирүүлэх; гадагш түүхий эд нэвтрүүлэх;* **цахилгаан нэвтрүүлэх чанар** (аливаа юмны цахилгаан дамжуулах чанар); 3. тараах, дэлгэрүүлэх; *суртал нэвтрүүлэх; тэргүүний туршлага, оновчтой саналыг ажилд нэвтрүүлэх; шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх.*

НЭВТРЭХ 1. юмны цаад талд цоолж гарах; *хадаас банзны цаад талд нэвтрэн гарчээ;* 2. шингэн зүйл, юманд шингэж цаад талд нь нойтон болох: *дээл бороонд нэвтрэв;* **үл нэвтрэх цаас** (юм нэвтэрдэггүй цаас); ☆ **архинд нэвтрэх** (архи бүх биед нь шингэсэн мэт болох); 3. ямар нэгэн газраар явж өнгөрөх; **хил нэвтрэх; нэвтрэх тэмдэгт, нэвтрэх бичиг** (хаалга үүд ба хязгаар боомтоор орох гарах зөвшөөрлийн бичиг; *та нэвтрэхээ үзүүл! нэвтрэх тэмдэгтээр оруулна);* 4. ш и л ж с э н харилцан **хөлээ** мэдэлцэх; *хэл нэвтэрч чадахгүй байна.*

НЭВТЭРХИЙ бүрэн, тодорхой, гүн; *нэвтэрхий мэдэх; нэвтэрхий сурах; нэвтэрхий харах;* **нэвтэрхий толь** (толь бичгийн маягаар хийсэн бөгөөд эрдмийн бүх буюу аль нэгэн хэсэг салбарыг тодорхойлсон, шинжлэх ухааны лавлах бичиг); **нэвтэрхий тольч** (нэвтэрхий толь бичиг зохиогч).

НЭВТЭСРЭХ нэвт үсрэх.

НЭВЧИХ шингэн зүйл юмны гадрын доогуур даацлан түрж газар авах; *идээр нэвчих; буглаж нэвчих; ус нэвчсэн газар.*

НЭВЧРЭХ булаг усны даацлан гарах.

НЭВШРЭХ 1. залхуу хүрэх, бие хүндрэх; *нэвширсэн халуун өдөр; бие нэвшрээд байна;* 2. хэтрэх, дэндэх; *нэвширтэл ачих; нэвширтэл жанчих; нэвширтэл унтах;* 3. новшрох, завааарах.

НЭГ (ЭН) 1. хоёроос нэгийг хасаад үлдсэн тоо; *нэгэн нэг нь нэг; нэгэн хоёр нь хоёр; нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино* з ү й р; 2. ганц; *нэг морь; нэг ширхэг ч тамхи татаж болохгүй;* **нэг ч** (нэгхэн; *бидний дотор энэ үгийг зөрчих хүн нэг ч үгүй, цөм зөвшөөрнө);* **нэг удаа** (ганц үе; *энд нэг удаа ирэв; тэд нэг удаа очив);* **нэг бус** (ганц бус, хэд хэдэн; *ажил тасалсан явдал нэг бус удаа болов);* **нэг шингэх эм** (нэгэн уухаар хэмжсэн хэмжээт эм); **нэг амиар** (нэг завдлагаар буюу нэг амьсгалаар; *энэ шувуу тэндээс нэг амиар нисч энд ирэв; энэ аягаар нэг айргийг би нэг амиар уув);* **нэг амьсгаагаар** (түргэн; *нэг амьсгаагаар уншин төгсгөх; нэг амьсгаагаар залгилав);* **нэг үе** (а. ганц удаа; *нэг үе баярлаж нэг үе гомдож байв;* б. нас ойролцоо; *нэг үеийн залуучууд;* в. ганц цагт); **нэгэн тал** (юмны нэгэн этгээдийн буюу нэгэн дундуур); **нэг суурь** (а. ганц зүйлийн олон малыг таслан сүрэглэсний нэгэн хэсэг; *хонин суурь; нэг суурь тэмээ;* б. дэвсгэр суудал хийхэд зориулж хийсэн эд барааны ганц хүн суух хэмээр хээ гарган хийсний нэгэн хэсэг; *нэг суурь хивс;* в. юмны ганц газар байх хэсэг; *нэг суурь өртөө; нэг суурь харуул);* **нэг ай** (ганц бүлэг, ганц аймаг, ганц хэсэгт багтах); **нэг анги** (хэсэг бүлэг юм; *нэг ангийн цэрэг; нэг ангийн сурагч; нэг анги болгосон юм);* **нэг иж** (нэг бүрэн бүтэн юм; *зохиолын нэг бүрэн иж бий);* **эрийн нэг** (энд

тэнд нэг нэгээр сарниж тарсан байдал; *барьж явсан цаасаа салхинд хийсгэж эрийн нэг болгочихов);* **нэг талыг баримтлах** (өрөөсгөл талыг барих); 3. нэгж хэм; **нэг жил** (а. дэлхийн бөмбөрцөг өөрийн явдлаар нарыг нэг удаа тойрч гүйцэх хэм, нэг жилийн ой болох хугацаа, өдрийн хоногоор гурван зуун жаран таван хоног орчим болно); **нэг сар** (а. жилийг арван хоёр хуваасан хэм; б. гуч, гучин нэг хоног; *нэг сарын амралт авлаа);* **нэг хоног** (а. өдөр шөнийн хорин дөрвөн цаг; б. нар ургахаас дараа өдрийн нар ургах хүртлэх хэм); **нэг өдөр** (а. нэг хоног; б. үүр цайхаас эхлэн бөрөнхий болох хүртлэх үе); **нэг цаг** (а. Европын зурхайн ёсны нэг хоногийг хорин дөрөв хуваасны нэг хувь, үүний дотор жаран минут багтана; б. шар цагаан зурхайн ёсны нэг хоногийг арван хоёр хуваасны нэг хувь, үүний дотор зуун хорин минут багтана); **нэг мөч** (цагийн хэмийн нэр, арван таван минут); **нэг эр** (тариалангийн газрын хэмжээ, таван өрлөг газар); **нэг өрлөг** (тариалангийн газрын хэмжээ, зургаан мүү буюу үр газар); **нэг үр** (тариалангийн газрын хэмжээ, бүгд гурван зуун жаран дөрвөлжин алд газар); **нэг хувиар** (тариалангийн газрын хэмжээ, нэг зуун үр газар); **нэг газар** (талбайн буюу хол ойрын хэмжээ, нэг зуун наян хос алд буюу гурван зуун жаран алд, таван зуун далан зургаан метртэй тэнцэнэ); **нэг хувь** (а. цагийн хэмийн нэр, жаран нарийн хувь (секунд); б. юмыг хувь бодож хуваасан хэмийн нэр; *гуравны нэг хувь);* **нэг дундуур** (юмны тэхий хагас буюу тал хувь; *мянганы нэг дундуур таван зуу);* **нэг дээс** (хэмжээ, гучин зургаан алд); 4. адил, ижил; **нэг төрөл** (юмны нэгэн нам, нэгэн угсаа, нэгэн чанартай); **нэг аймаг** (а. амьтны ганц аймагт хуваасан нь; б. аймгаар хуваасан хувиарлал); **нэг нам** (санаа явдал нэгдсэн хэсэг хүн); **нэг мөр** (а. аливаа юмны нэгэн адил маяг журамтай болох: б. аян тал дагуу; *би явбал, нэг мөрөөр бүтээн цриж болох хэрэг байна;* в. журам зураас; *нэг мөр бичиг; нэг мөр нэмээд зур!);* **нэг дуугаар** (олны нэгэнт дуудах буюу хашгирмагц нэгэн зэргээр ирэх очих, үйлдэх хийх; *нэг дуугаар цугларав; нэг дуугаар зөвшөөрөв);* **нэг санаа** (а. олон хүний харилцан нийлэлцсэн санал; б. санаа зорилт урвалтгүй бат); **нэг зорилго** (адил санаа); *айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг* з ү й р; 5. аливаа үйл явдлын хам, зэрэг, жигд; **нэг дэсээр** (үйл явдлын зэргээр буюу завсар зайгүй дараа дараагаар давхцах); **нэг зэргээр** (сацуу; *та нар арван хоёр цагт нэг зэргээр ир! таван цагт нэг зэргээр тарна);* **нэгэн хамтаар** (цугаар; *тэд нар нэгэн хамтаар ирсэн; бид нар нэгэн хамтаар явсан);* 6. дахин; *би бас нэг дуулъя; бас нэг ууя;* 7. я р и а нэг удаа, түр зуур; *чи нэг очоод ярь; би нэг хэлээд орхиё; нэг жаахан унтаад авлаа.* ᠨᠢᠭᠡ

НЭГБҮР тусбүр, тус тус, бүгдээр; *ард түмэн нэгбүрийн ариун үүрэг; хүн нэгбүр оролцох ёстой; ямаа нэгбүрийг самнах хэрэгтэй.* ᠨᠢᠭᠡᠪᠦᠷ

НЭГДМЭЛ нийлж нэгдсэн юм; *нэгдмэл санал; нэгдмэл фронт; нэгдмэл хүч; нэгдмэл нам.* ᠨᠢᠭᠡᠳᠮᠡᠯ

НЭГДҮГЭЭР дэс дараалсан тоо; *нэгдүгээр зүйл; нэгдүгээр сар; нэгдүгээрт ингэж бодох хэрэгтэй; нэгдүгээр гурил; нэгдүгээр зэргийн тамхи..* ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠡᠡᠷ

НЭГДҮҮЛЭХ нэгдэхийн үйлдүүлэх хэв. ᠨᠢᠭᠡᠳᠦᠦᠯᠡᠬᠦ

НЭГДЭЛ 1. нэгдсэн үйлийн нэр, бөөгнөрөл; **нэгдэл нягтрал** х о р ш.; *бат нэгдлээ сахин хамгаалах;* 2. үйлдвэрлэлийн хэрэгслийг нийгэмчилж, хөдөлмөрөө хоршсон хоршоолол; *«Мандах» нэгдлийн сайчууд цугларан ирлээ; нэгдлийн гишүүд;* **нэгдлийн хөдөлмөр зохион байгуулалт** (нэгдлийн ажиллах хүчийг нийгмийн үйлдвэрлэлийн салбарт зохистойгоор хувиарлан оролцуулах зохион байгуулалтын явц); **нэгдлийн ерөнхий хороо** (нэгдлийн бүх гишүүдийн хурлаар сонгогдож, нэгдлийн өдөр тутмын ажлыг зохицуулан удирдах үүрэг хүлээсэн хүмүүс); **нэгдлийн дарга** (нэгдлийн ерөнхий хорооны дарга); **нэгдлийн үлгэрчилсэн дүрэм** (нэгдлийн санхүү, аж ахуй, зохион байгуулалтын үйл ажиллагааны үндсэн зарчмыг илэрхийлсэн дүрэм). ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠡᠷ

НЭГДЭХ I нийлэх, нэг болох, хамтрах; *орон бүхний хөдөлмөрчид нэгдэх хэрэгтэй; малчин бүхэн нэгдэж хамтран аж төрөхөөс дээр зөв замгүй.* ᠨᠢᠭᠡᠳᠡᠬᠦ

НЭГДЭХ II нэг дэх, дэс тооны нэгдүгээрт тохиолдсон нь; *нэгдэх өдөр; нэгдэх хуудас.* ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠡᠷ

НЭГЖИГДЭХ нэгжихийн үйлдэгдэх хэв. ᠨᠢᠭᠵᠢᠭᠳᠦᠬᠦ

НЭГЖИЛТ нэгжих үйлийн нэр. ᠨᠢᠭᠵᠢᠯᠲᠡ

НЭГЖИХ ямар нэгэн нуусан, зүй бус юмыг эрж олохоор тусгайлан хайх; *баривчлагдсан этгээдийн биеийг нэгжин үзэв; гэр нэгжих.* ᠨᠢᠭᠵᠢᠬᠦ

НЭГЖЛЭГ аливаа нууж далдалсан юмыг албан ёсоор үзэх үзлэг. ᠨᠢᠭᠵᠢᠯᠡᠭ

НЭГЖҮҮЛ нэгжилт; *нэгжүүл хийх.*

НЭГЖҮҮЛЭХ 1. нэгжихийн үйлдүүлэх хэв; 2. нэгжигдэх.

НЭГЛИЙ бутач; *нэглий хүүхэд.*

НЭГМӨСӨН 1. бүрмөсөн; *дахин буцаж ирэхгүй нэгмөсөн явахаар шийдвэрлэв;* 2. нэг зэрэг хамтад; *идэш уушны зүйлийг маргааш нэгмөсөн авна.*

НЭГНЭЭ нэгэнт; *нэгнээ хэлсэн үгээ буцалтай биш.*

НЭГТГҮҮЛЭХ нэгтгэхийн үйлдүүлэх хэв.

НЭГТГЭГДЭХ нэгтгэхийн үйлдэгдэх хэв.

НЭГТГЭЛ нэгтгэсэн, нэг болгосон нь; *нэгтгэл бүртгэл; нэгтгэл товчоо.*

НЭГТГЭХ нэг болгох, хамтатгах, нийлүүлэх; *аянчид юмаа нэгтгэв; жижиг үйлдвэрүүдийг нэгтгэн томсгов; санаа зорилтыг нэгтгэх.*

НЭГТЭЙ 1. нэгэнт л; *чи нэгтэй тийшээ явахаас хойш, өөр хүн яваад яах вэ;* 2. нэг газар, ямар нэг юманд хийх; *чи үүнийг нэгтэйвээ далд хийчихээрэй.*

НЭГТЭЙГҮҮР нэгэнтээгүүр.

НЭГШИХ чийгнээс болж юм гутах, муудах; *нэгшсэн ааруул; аарц нэгших; мах нэгших.*

НЭГЭНТ энэ нэгэн удаа, дахилтгүй, эргэлтгүй; *бид нэгэнт буудалласан тул дахин хөдлөхгүй; хэрэг нэгэнт ийм болов.*

НЭГЭНТАА нэгэн удаа; *нэгэнтаа эргэж харав; нэгэнтаа дуудав.*

НЭГЭНТЭЭГҮҮР нэг талаар; *нэгэнтээгүүр би хөдөлмөрийн чадваргүй болсон хүн, нөгөөтээгүүр над туслах тэтгэх хүн байхгүй.*

НЭЖГЭЭД тус тус нэг; *хүн тутам нэжгээд морь ногдоно.*

НЭЖЭЭД нэжгээд, нэг нэг.

НЭЛ элбэг үлэмж, өргөн хэмжээтэй; *мод нэл ногоон болжээ; цас нэл бүрхжээ; бороо газар сайгүй нэл орсон байна.*

НЭЛГЭР 1. ихээхэн хэмжээний шингэн юм тарж хальсан, тунасан нь; *их нуурын нэлгэр ус; нэлгэр тос;* 2. цэлгэр уудам; *нэлгэр сайхан тал хөндий.*

НЭЛДГЭР дэлбэгэр, далбагар, дэлдэн, нэвсгэр; *нэлдгэр чихтэй малгай.*

НЭЛДИЙЛГЭХ нэлдийхийн үйлдүүлэх хэв. нэлдгэр болгох; *том дээл нэлдийтэл өмсчээ.*

НЭЛДИЙХ нэлдгэр болох; *малгайны чих нэлдийж унжсан байв.*

НЭЛДЭГНЭХ нэлдгэр юмны нэлдэг нэлдэг хийж хөдлөх.

НЭЛИЙ ихэд асгасан шингэн зүйл;

НЭЛИЙЛГЭХ нэлийхийн үйлдүүлэх хэв.

НЭЛИЙХ нэлгэр болох, цэлийх; *Сэлэнгэ мөрөн нэлийж харагдана; нэлийсэн тал газар.*

НЭЛМИЙХ нэлэмгэр болох; *нэлмийсэн чихтэй малгай өмсчихжээ.*

НЭЛМЭГНҮҮЛЭХ нэлмэгнэхийн үйлдүүлэх хэв.

НЭЛМЭГНЭХ нэлэмгэр юмны нэлмэг нэлмэг хөдлөх.

НЭЛМЭЛЗЭХ нэлэмгэр юмны нэлмэс нэлмэс хөдлөх.

НЭЛХГЭР 1. нэлэмгэр элбэг том; *нэлхгэр дээл;* 2. нялцгар, нялхайсан юм.

НЭЛХИЙЛГЭХ нэлхийхийн үйлдүүлэх хэв.

НЭЛХИЙХ I нэлхгэр болох.

НЭЛХИЙХ II нилэг муухай үнэр гарах.

НЭЛЭЛЗҮҮЛЭХ нэлэлзэхийн үйлдүүлэх хэв, цэлэлзүүлэх.

НЭЛЭЛЗЭХ 1. нэлгэр юмны нэлс нэлс хөдлөх; 2. цэлэлзэх.

НЭЛЭМГЭР элбэг том юм; *нэлэмгэр цув өмссөн нь дан ч аягүй харагдав.*

НЭЛЭНХИЙ даяар, нийт; *энэ жил нэлэнхийдээ сайхан зун болов; энэ бороо нэлэнхийдээ адил оржээ; бид нэлэнхийдээ бичиг үсэг мэдэх болов.*

НЭЛЭНХИЙДЭХ хэтэрхий нэлэнхий болох.

НЭЛЭНХИЙРЭХ нэлэнхий болох.

НЭЛЭНХИЙШИХ нэлэнхий шинжтэй болох.

НЭЛЭЭД нилээд, милээд.

НЭМБЭР нэмсэн юм, нэмүүр, нэмэлт.

НЭМЛЭГ юмны дээр нэмэх нь; *нэмлэг нь бага байна.*

НЭМНҮҮЛЭХ 1. нэмнэхийн үйлдүүлэх хэв; 2. нэмнэгдэх.

НЭМНЭГДЭХ нэмнэхийн үйлдэгдэх хэв.

НЭМНЭХ нэмнээ, тохох нөмрөгийг малын нуруунд нөмөргөх; *тугал бяруугаа хүйтэнд нэмнэж байв.*

НЭМНЭЭ малыг нэмнэх иєгий зэрэг юм; *тугалын нэмнээ; унаганы нэмнээ; хурдны морины нэмнээ.*

НЭМСХИЙХ баахан нэмэх.

НЭМҮҮ илүү; *над нэмүү өгөх хэрэгтэй;* **нэмүү өртөг** (хөлсний ажилчдаас тодорхой цагт бүтээсэн хөдөлмөрийн хөлсний төлөгдөөгүй хэсэг).

НЭМҮҮЛЭХ нэмэхийн үйлдүүлэх хэв;

НЭМҮҮН I илүүхэн, ихээхэн; *над нэмүүн өгөөрэй; нэмүүний нь чи ав!*

НЭМҮҮН II 1. уян зөөлөн; *нэмүү хөрстэй газар;* **дөлөөн нэмүүн** х о р ш.; 2. элдэг, дөлгөөн; *нэмүүн аштай.*

НЭМҮҮР нэмэр, нэмбэр; *муу явдал бага ч атугай гутамшгийн нэмүүр.*

НЭМҮҮРЭХ зөөлрөх, зөөлөн болох; *газар нэмүүрэх; арьс дэвтэж нэмүүрэв.*

НЭМҮҮХЭН баахан нэмүүн; *наад хоолноосоо нэмүүхэн хийгээд өгөөрэй.*

НЭМЭГДҮҮЛЭХ нэмэгдэхийн үйлдүүлэх хэв; *үнэ нэмэгдүүлэх; хүч нэмэгдүүлэх; малын тарга тэвээргийг нэмэгдүүлэх.*

НЭМЭГДЭЛ нэмж өгсөн юм; *нэмэгдэл цалин; нэмэгдэл татвар.*

НЭМЭГДЭХ нэмэхийн үйлдэгдэх хэв, ихсэх; *борооны дараа голын ус нэмэгдэв; хүндийн жин нэмэгдэх.*

НЭМЭЛТ нэмэр, нэмбэр, нэмсэн юм; *нэмэлтий нь өг! нэмэлтий нь ихээхэн.*

НЭМЭЛЦҮҮЛЭХ нэмэлцэхийн үйлдүүлэх хэв.

НЭМЭЛЦЭХ нэмэхийн үйлдэлцэх хэв; *үнэ нэмэлцэх; ам нэмэлцэх; хушуу нэмэлцэхээр хуруугаа нэмэлц.*

НЭМЭР I. нэмлэг, нэмж өгөх юм; *нэмэр өгч арилжих; нэмрий нь их бол солих гэнэ;* 2. тусламж, тус; **тус нэмэр, нэмэр сэмэр, хувь нэмэр нэмэр хандив** х о р ш.; *ажилд нь нэмэр болох; энх тайвныг хамгаалах хэрэгт хувь нэмрээ оруулах; нэмэр авах;* **далайд дусал нэмэр** (бага боловч тус).

НЭМЭРЛҮҮЛЭХ нэмэрлэхийн үйлдүүлэх хэв, нэмэр болгох.

НЭМЭРЛЭХ 1. нэмэр болгох, юмны арвидах, хуримтлахад оролцох; *нэмэрлэсээр байтал тоондоо хүрэв; би хувиа нэмэрлэв;* 2. нэмж муулан хэлэх; *даарь дээр нь давс нэмэрлэх.*

НЭМЭХ юмны дээрээс басхүү тавьж их буюу олон болгох; *хоёр дээр хоёрыг нэмэхэд дөрөв болох; хүн нэмэн ирж байв; улам нэмэх, өрнөн дэлгэрэх* (бөхийн цол); **нэмэх тэмдэг** (чагт) (+) (хэлбэртэй тэмдэг, тооны ухаанд тоог хооронд нь нийлүүлэх буюу эерэх хэмжигдэхүүнийг тэмдэглэнэ).

НЭМЭЭС 1. нэмсэн дээр нэмэх нь; *нэмээс нь ихдэх, багадах; нэмээсий нь тохируулах;* 2. тээр дараас; *нэмэр болох гэсэн биш нэрмээс болов.*

НЭМЭЭСЛЭХ нэмээс бий болгох, нэмсэн дээр нэмэх.

НЭН 1. маш, асар; *нэн их; нэн ховор; өдийд бороо орвол нэн сайн;* 2. бүр, бүр ч; *нэн ялангуяа; нэн ч; нэн ялангуяа ус шалбаагтайд маш болгоомжлон явах хэрэгтэй, нэн ч бэрх;* **нэн машид** (тэсгэлгүй); **нэн түрүүнд** (юуны өмнө).

НЭНДҮҮ дэндүү, хэтрүү; *нэндүү их байна; нэндүү зантай хүн.*

НЭНДҮҮЛЭХ нэндэхийн үйлдүүлэх хэв.

НЭНДЭХ дэндэх, хэтрэх, хэтэрхийдэх; *бороо нэндэх төлөвтэй болов; ус чийг нэндвэл ургамлын шим чанар муудахад хүрнэ.*

НЭР 1. юм, үзэгдлийг үгээр тэмдэглэсэн нь; *цэцгийн нэр; сонины нэр; далдуу нэрт мод; олон нэр төрлийн бараа бий;* **нэр төрөл** х о р ш.; 2. хүнийг анх төрөхөд ногдуулан зүүлгэж дуудах үг, бас мал адгуусанд бий; *нэрээр нь дуудах; өөр нэртэй явж байв; халзан нэрт үнээгээ саагаагүй байлаа; тэр нохойн нэр-хүдэр;* **таны нэр хэн бэ?** (таны алдар хэн бэ?); *нэр нэгтийн чих нэг з ү й р;* **нэр хамтрах** (аливаа үйлдсэн хийсэн зүйлд хоёр буюу түүнээс дээш нэр оруулах);

нэр дэвшүүлэх (сонгууль томилолт зэрэгт нэр нь орох; *сонгуулийн тойрогт нэр дэвшүүлэв);* **нэр ташлах** (нэр цохсон хүний дараа дэдлүүлэн нэрийг зааж оруулах); **нэр цохох** (олны дотроос оноох); **нэр зээлдэх, нэр зээлэх** (бусдын нэрийг өөртөө ашиг завшаан болгож ашиглах); **нэр цээрлэх** (жинхэнэ нэрийг хэлэхгүй, ямар нэгэн нэрээр орлуулан нэрлэх); **бага нэр** (бага залуу ахуй цагийн нэр); **нэр үг** (хэлний зүйн нэг ай); **жинхэнэ нэр** (хэн юү гэсэн асуултад хариулах үг); **бодисын нэр** (материаллаг үзэгдэл юмны нэр); **хийсвэр нэр** (бодит биш ухагдахуун илэрхийлэх үг); **оноосон нэр** (нэгэн төрлийн олон юмны дотроос бусдаас ялгаж тусгайлан өгсөн нэр); **нэр томъёо** (шинжлэх ухаан, техникийн аливаа явцуу ухагдахууныг тэмдэглэсэн үг); **нэр томъёоны судлал** (нэр томъёог тогтоох, судлах тухай судлал); **орлогын нэр** (орсон юмыг дараалан бичсэн жагсаалт); **зарлагын нэр** (зарсан юмыг дараалан бичсэн жагсаалт); **нэрийн хуудас** (овог нэр, хаягаа бичсэн жижиг хэрчмэл цаас); **нэрийн цэс** (хүний нэрсийг дэс дараалан бүтээсэн бүртгэл); 3. алдар, дуурсгал; *нэрд гарсан эрдэмтэн; нэртэй дуучин; ногдсон үүргээ нэр төртэй биелүүлэх;* **нэртэй зартай** (сайн муу нэр нь олонд алдаршсан); **нэр бүтэн** (нэр нь гүтаж муудаагүй); **нэр олох** (а. нэртэй болох; б. нэр нь алдарших); **нэр хүнд** (нэр алдар); **нэр муутай** (нэр алдар нь гутаж доройтсон); **нэр сайтай** (нэр алдар нь гутаж муудаагүй, сайн); **нэр сүр** (нэр алдар, нэр хүнд); **нэр төр** (алдар хүнд); **нэр бүхий** (нэр дурдагдсан); **нэр гутах, нэр гутрах** (нэр алдар доройтож муудах); **нэр хугарах** (нэр алдар муудах; *хүний газар нэр хугарахаар, өөрийн газар яс хугар* з үй р); **нэр алдарших** (нэр алдар нь олон түмний дотор түгж дэлгэрэх); **нэрд гарах** (нэр алдар нь нийтийн дотор товойж тодрох); **нэр харах** (а. нэрээ бодох; б. нэр алдар, эрх тушаалы нь харгалзаж ялгавартай үзэх); **нэр цэвэрших** (нэр гутаж муудахад хүрсэн шалтгаан нь үгүй болж нэр нь цэвэр болох, цагаадах): **нэрээ хугалах** (нэрээ гутаах үйл явдлыг өөрөө үйлдэх); **нэрээ цэвэрлэх** (нэрээ гутаасан үйлээ цэвэр болгох, цагаатгуулах); **нэрээ цагаатгах** (нэрээ цэвэрлэх); **нэрээ бодох** (а. нэр алдраа хайрлаж хамгаалах; б. нэрэлхэх); **нэрээ хайрлах** (нэр алдраа хайрлан арчлах, хамгаалах); **сайн нэр хүсэвч олдохгүй, муу нэр хусавч арилахгүй** (сайн нэр олох гэдэг маш бэрх, нэгэнт муу нэр олбол түүнийг арилгахад бүр ч бэрх); **хүн нэрээ, тогос шувуу өдөө** с э ц э н (нэрээ маш эрхэмлэн хайрлах нь чухал); ☆ **нэр хэмээх** (зэмдэглэх, хагас дутуу гүйцэтгэх; *бичиж өгсөн нэр хэмээгээд явжээ);* **нэрийн өмнөөс** (төлөөнөөс). ᠨᠡᠷ᠎ᠡ ᠶᠢᠨ

НЭРВЭГДҮҮЛЭХ нэрвэгдэхийн үйлдүүлэх хэв. ᠨᠡᠷᠪᠡᠭᠳᠡᠬᠦᠯᠬᠦ

НЭРВЭГДЭХ нэрвэхийн үйлдэгдэх хэв, өвчин зовлонд дарагдах, зүдрэх, зовох, өртөх; *өвчинд нэрвэгдэх; зовлон гачигдалд нэрвэгдэх; зудад нэрвэгдэх.* ᠨᠡᠷᠪᠡᠭᠳᠡᠬᠦ

НЭРВЭХ нэрмэх, нэмээслэх. ᠨᠡᠷᠪᠡᠬᠦ

НЭРВЭЭС нэрмээс, нэрвэх юм. ᠨᠡᠷᠪᠡᠭᠦᠰ

НЭРГҮЙ 1. нэрийдсэн нэр байхгүй; **нэргүй хуруу** (ядам хуруу); 2. нэр муутай болсон, нэр хүндээ алдсан нь. ᠨᠡᠷᠭᠦᠢ

НЭРИЙДЛЭГ нэрийдэх үйлийн нэр, нэрийдэл. ᠨᠡᠷᠢᠶᠢᠳᠯᠡᠭ

НЭРИЙДЭЛ нэр төдий явдал, үнэн биш шалтгаан; *хөдөө гарах нэрийдлээр; хичээлд суух нэрийдлээр гэрээс гарч бөмбөг өшиглөн нааддаг байв.* ᠨᠡᠷᠢᠶᠢᠳᠡᠯ

НЭРИЙДЭХ нэр өгөх, нэрлэх; *эндэхийн хөдөлмөрчид нэгдлээ «Туяа» гэж нэрийдэв: юу гэж нэрийдэх вэ?* 2. зөвхөн нэр төдий гүйцэтгэх, нэр хэмээх; *хийсэн гэж нэрийдэх.* ᠨᠡᠷᠢᠶᠢᠳᠡᠬᠦ

НЭРИЙТГЭЛ юманд зүүсэн нэр; *нэрийтгэл нэр.* ᠨᠡᠷᠢᠶᠢᠲᠭᠡᠯ

НЭРЛҮҮЛЭХ нэрлэхийн үйлдүүлэх хэв ᠨᠡᠷᠯᠦᠦᠯᠬᠦ

НЭРЛЭГДЭХ нэрлэхийн үйлдэгдэх хэв. ᠨᠡᠷᠯᠡᠭᠳᠡᠬᠦ

НЭРЛЭХ 1. хүн, юмны нэрийг хэлэх, нэрээр нь нэрлэх; 2. юманд нэр өгөх; **нэрлэхийн тийн ялгал** (монгол хэлний долоон тийн ялгалын нэгдүгээр тийн ялгал). ᠨᠡᠷᠯᠡᠬᠦ

НЭРМҮҮЛЭХ 1. нэрмэхийн үйлдүүлэх хэв; 2. нэрмэгдэх, нэрвүүлэх. ᠨᠡᠷᠮᠦᠦᠯᠬᠦ

НЭРМЭГДЭХ нэрмэхийн үйлдэгдэх хэв, нэрвэгдэх. ᠨᠡᠷᠮᠡᠭᠳᠡᠬᠦ

НЭРМЭЛ нэрж хийсэн, нэрсэн нь; *нэрмэл ус; нэрмэлийн архи.* ᠨᠡᠷᠮᠡᠯ

НЭРМЭХ муудсан дээр нэмэх, муудаад байхад улам төвөг болох, нэрвэх; *ядаж байгаа юмыг чи битгий нэрмээд бай!* ᠨᠡᠷᠮᠡᠬᠦ

НЭРМЭЭС нэрмэх юм, муудсан юманд улам төвөг учруулах зүйл, нэрвээс; *нэмэр болохоосоо нэрмээс болох* х у у ч. ᠨᠡᠷᠮᠡᠭᠦᠰ

НЭРМЭЭСЛЭХ нэрмэсэн дээр бас нэрмэх, нэрвэх. ᠨᠡᠷᠮᠡᠭᠦᠰᠯᠡᠬᠦ

НЭРС I у р г а м а л хөхөвтөр өнгөтэй, шүүс ихтэй, сайхан амттай жимсгэнэ, бутад ургана.

НЭРС II олон нэр; *нэрсийн жагсаалт хийх; нэрсийн жагсаалтад тэр тэр нарыг үлдээх санал байна.*

НЭРТ нэр бий, нэрд гарсан нь; *нэрт эрдэмтэн; нэрт зохиолч;* **нэрт цэцэг** у р г а м а л (иш, салаа, навч нягт, ялма мод мэт, цэцэг улаан шар цагаан гурван зүйл).

НЭРТЭЙ 1. нэр бүхий; 2. нэр алдар гарсан нь.

НЭРҮҮЛЭХ нэрэхийн үйлдүүлэх хэв.

НЭРШИХ нэрийн шинжтэй болох, аль нэг нэрээр олонд алдарших; *урьд (ногоон дээлт) гэж нэршсэн билээ.*

НЭРШҮҮЛЭХ нэршихийн үйлдүүлэх хэв.

НЭРЭЛХҮҮ нэрэлхэг.

НЭРЭЛХЭГ нэрэлхэх заншилтай; нэрэлхүү; *нэрэлхэг хүн.*

НЭРЭЛХЭХ ичгүүрэн хуурмаг зан гаргаж аашлах; *та нэрэлхэлгүй идэж уугтун; нэрэлхээд нэрээ идэхгүй* х у у ч ; *нэрэлхээд гоёж эс чаджээ; нэрэлхээд, огт мэдэхгүй юмыг ч сайн мэддэг гэж хэлэв; нэрэлхэн мэдэмхийрэх.*

НЭРЭМЖИТ хүн юмны нэрээр нэрлэгдсэн зүйл; *Сүхбаатарын нэрэмжит хэвлэх үйлдвэр.*

НЭРЭМШИХ нэрэмжит болгосноор нэрших.

НЭРЭХ I. шингэн буюу хатуу бодисыг бүцалгах буюу халаах замаар уул бүрэлдэхүүнд нь задлан салгах; *нефть нэрэх; давирхай нэрэх; архи нэрэх;* 2. амны тамхийг гаансанд утгаж авах; *тамхиа нэрж суув; галзуу улаан тамхиа ганц нэг нэрж суув* (үлгэр).

НЭС: нэс муу туйлын муу, адгийн муу.

НЭТ урьдахаасаа улам дор болсон нь; *нэт болох; хүйтэн, өвлөөсөө нэт байна.*

НЭТРҮҮ хэтрүү.

НЭТРҮҮЛЭХ нэтрэхийн үйлдүүлэх хэв, хэтрүүлэх.

НЭТРЭХ урьдахаасаа улам дордох, хэтрэх; *улам нэтрэх; тамхи татах нь бүр нэтэрчээ.*

НЭХДЭС бие махбодын хэсэг бүлэг эс; *холбох нэхдэс; булчин нэхдэс;* **нэхдэс судлал** (ургамал амьтны бие махбодын нэхдэсийн зохион байгуулалтыг судлах ухаан).

НЭХИЙ хонь ямааны элдсэн ба түүхий арьс; *нэхий дээл;* **өнгө нэхий** (өнгө татаагүй, арьсаараа байгаа).

НЭХЛИЙ нэглий.

НЭХЛЭГ бараа нэхэх үйл; нэхлэгийн ажил.

НЭХЛЭГЧ бараа нэхэх хүн.

НЭХМЭЛ I. сүлжиж хийсэн эд бараа; *торгон нэхмэл; бөс нэхмэл; нэхмэлийн үйлдвэр;* 2. нэхэж үйлдсэн, нэхсэн нь; *нэхмэл бээлий.*

НЭХМЭЛЧ (ИН) нэхэх ажил хийгч, нэхэгч.

НЭХҮҮЛ 1. нэхэж яваа юм; *нэхүүлийн хүн ирэв; нэхүүл бичиг явуулав;* 2. дагуул; **нэхүүл дагуул** х о р ш . .

НЭХҮҮЛЭХ 1. нэхэхийн үйлдүүлэх хэв; 2. нэхэгдэх.

НЭХЭГДЭХ нэхэхийн үйлдэгдэх хэв.

НЭХЭГЧ I нэхмэлч.

НЭХЭГЧ II нэхэж шаардах үүрэг бүхий хүн; *өр нэхэгч.*

НЭХЭЛ: нэхэл дагал болох авд салахгүй дагах; **нэхэл дагал** х о р ш . .

НЭХЭЛТ I нэхэх үйлийн нэр; *чиний нэхэлт ирээд байна.*

НЭХЭЛТ II нэхээс; *нэхэлт сайтай эд.*

НЭХЭМЖЛҮҮЛЭХ нэхэмжлэхийн үйлдүүлэх хэв.

НЭХЭМЖЛЭГ өр авлага нэхэж шаардсан хуудас; *албан газарт нэхэмжлэг явуулах.*

НЭХЭМЖЛЭГДЭХ нэхэмжлэхийн үйлдэгдэх хэв.

НЭХЭМЖЛЭГЧ нэхэмжлэх үүрэг гүйцэтгэгч; *өр нэхэмжлэгч.*

НЭХЭМЖЛЭЛ нэхэмжлэх үйлийн нэр; *нэхэмжлэл бичиг авчрах хэрэгтэй.*

НЭХЭМЖЛЭХ нэхэх, шаардах; *өр нэхэмжлэх; хэрэг нэхэмжлэх.*

НЭХЭХ I эд барааг сүлжин хийх; *бөс нэхэх; торго нэхэх; ойлс нэхэх.*

НЭХЭХ II 1. юмыг аль ац гэж шаардах; *өр нэхэх; хүүхэд чихэр нэхэж байна;* 2. сөхөн гаргаж ирэх, шаардах; нэхэж мөрөөдөх; **нэхэж өргөмжлөх** (үхсэн хойно өргөмжлөх); **хэрэг нэхэх** (хэргийг сөхөн гаргаж заалдах); 3. тэмцээн зэрэгт дийлдсэнийг хариулан дийлэхээр дахин тэмцэх, нэхэж наадах; **даагаа нэхэх, шовхоо нэхэх** (хожигдсон буюу барилдаж унасан этгээд хариу дийлэхээр дахин үзэлцэх); 4. гүйцэхээ хөөх; **нэхэх хөөх** х о р ш.; *нэхэж дагах;* **улаа нэхэх** (улаанд унуулсан морийг буцааж авахаар дагаж явах).

НЭХЭЭС барааны сүлжээс; *нарийн нэхээстэй эд.*

НЭШ 1. х у у ч и р с а н суманд наалдсан гөрөөсний цус; 2. шархадсан гөрөөснөөс дуссан цус.

НЭШЛЭХ хувилж гашлах, гутах; *сүү нэшлэх; тараг нэшлэх.*

НЭЭГДЭХ нээхийн үйлдэгдэх хэв; *хаалга нээгдэхгүй болжээ.*

НЭЭГЧ 1. нээх хүн; *хурал нээгч;* 2. ямар нэгэн юмыг онгойлгох нээх үүрэг бүхий хүн; *хаалга нээгч.*

НЭЭЛГИЙ авдар савны хавхаг таглаа; *авдарны нээлгий; тогооны нээлгий.*

НЭЭЛГЭХ нээхийн үйлдүүлэх хэв, нээхэд хүргүүлэх.

НЭЭЛТ нээж олсон юм; *шинжлэх ухааны шинэ нээлт.*

НЭЭЛХИЙ нээлгий.

НЭЭРЭЭ үнэхээр, чухам үнэн; *чи нээрээ мэдэх үү? тэр нээрээ байх шүү; нээрээ хэлж байна уу? нээрээ сайн морь байна билээ.*

НЭЭХ онгойлгох, цалайлгах, хаалттай бүтүү юмыг задгай онгорхой болгох; *авдар нээх; хаалга нээх; хурал нээх; захиа нээх; уурхай нээх;* **ам нээх** (анх удаа хэлэх); **нүд нээх** (а. юм их үзэж учир таних; б. нялх амьтны анх удаа харах): **нээсэн ханш, ханш нээх** (билгийн улирлын зурхайн ёсны жилийн хорин дөрвөн улирлын нэг, аргын улирлын дөрөвдүгээр сарын эхний арав хоногийн дотор тохиолдоно, газар хагалж тариа тарих үес).

НЯ-БО нягтлан бодох, нягтлан бодогч.

НЯВТАЛ нимгэн тачир; *үс нявталтай нэхий; газар нявтал гарчээ.*

НЯВТАЛДАХ хэтэрхий нявтал болох.

НЯВТАЛРАХ нявтал болох.

НЯВТАЛХАН үстэй юмны баахан нявтал.

НЯГ чигжүү, нягт; *няг ургасан шугуй; няг нэхээстэй бараа.*

НЯГТ 1. чамбай, шигүү, бага зайд ихээхэн хэмжээтэй багтсан нь; *нягт эд; нягт бодис;* **нягт шар** у р г а м а л (хальсархаг бөгөөд бяцхан мөнх ногоон навчтай, жижгэвтэр мод, дулаан оронд ургана); 2. чигжүү, шигүүн; *нягт ургасан өвстэй газар;* 3. ш и л ж с э н хянамгай, суурьтай болгоомжтой; *нягт хүн;* **нягт нямбай** х о р ш..

НЯГТАРХАХ нягт болох гэж оролдох, нягтаа гайхуулах.

НЯГТДАХ хэтэрхий нягт болох.

НЯГТДУУЛАХ нягтдахын үйлдүүлэх хэв.

НЯГТЛАХ нарийвчлан хянах, хянаж шалгаруулах; *нягтлан байцаах; нягталж үзэх; нягтлан бодох.*

НЯГТЛУУЛАХ нягтлахын үйлдүүлэх хэв.

НЯГТРАЛ нягтрах үйлийн нэр; *нягтрал сайтай; нягтрал муутай.*

НЯГТРАХ нягт болох, бат болох.

НЯГТРУУЛАХ нягтрахын үйлдүүлэх хэв, нягт болгох.

НЯДГАЛАХ удгалах, удган бөөгийн бөөлөх.

НЯДГАН удган, эм бөө.

НЯДЛААН алаан, хядаан; *цуст нядлаан.*

НЯДЛАХ алах; *мал нядлах.*

НЯДЛУУЛАХ нядлахын үйлдүүлэх хэв.

НЯЛ I: **нял нял хийх** хэл дэвсч нушлан ярих.

НЯЛ II: **нял цэцэг** у р г а м а л ой мод, нуга намаг, тал газар ургадаг олон наст өвсөрхөг ургамал, төрөл зүйл олон, зарим нэгээр үнэртэн хийнэ.

НЯЛАЛДАХ нялахын үйлдэлдэх хэв.

НЯЛАХ норшин нялцгай юмыг ихээр түрхэх; *байшинд шавар нялах; дээлдээ будаг нялж орхижээ.*

НЯЛУУЛАХ нялахын үйлдүүлэх хэв.

НЯЛГА 1. загасны үрийн булчирхай; 2. загасны үрийн шингэн.

НЯЛГАДАХ норшин нялцгай юмыг хэмжээ томьёогүй түрхлэх; *шавар нялгадах; тос нялгадах.*

НЯЛГАДУУЛАХ нялгадахын үйлдүүлэх хэв.

НЯЛГАНАХ 1. норшин, нялгар нялцгар юмны нялга нялга хийх; *тос нялганах; шавар нялганах;* 2. зөөлөн илбэрүүн юмны маш эелдэг таалмаар байх; *нялганасан зөөлөн хөрстэй арьс;* 3. ш и л ж с э н нялуун зан гаргах; *нялганасан сүрхий баштай амьтан.*

НЯЛГАНУУЛАХ нялганахын үйлдүүлэх хэв.

НЯЛЗААХ нялзахад хүрүүлэх, нялзуулах, халдаах; *хийсэн хэргээ бусдад нялзаахыг оролдов.*

НЯЛЗАХ 1. бага юм ихээхэн юманд тарж наалдах, наалдан сарних; *нялзан үрэгдэх; нялзаж үгүй болох;* 2. ш и л ж с э н бусдын хэрэг халдах.

НЯЛЗРАЙ нялх; **нялх нялзрай** х о р ш.; *нялзрай хурга; нялзрай хүүхэд.*

НЯЛЗРАЙДАХ хэтэрхий нялзрай болох.

НЯЛЗУУЛАХ нялзахын үйлдүүлэх хэв.

НЯЛМАЛАХ байн байн нялмах.

НЯЛМАС уйлах зэрэгт нүднээс гоожих шингэн зүйл, *нулимс; нялмасны булчирхай; нялмас гарах.*

НЯЛМАХ шүлс цэрийг гаргаж хаях; *шал дээр нялмаж болохгүй гэж бичсэн байв.*

НЯЛМАЧИХ няламлах, нулимлах.

НЯЛМУУР шүлс цэр хаях сав, нулмуур; *эмнэлгийн газар цэвэрхэн сияан нялмуурууд байв.*

НЯЛТЛАХ нялтрах, хуулах, холтлох.

НЯЛТРАХ юмны өнгө хөрс хуурах, холтрох; *газрын хөрс нялтрах; гарын арьс нялтрах.*

НЯЛУУДАХ хэтэрхий нялуун болох.

НЯЛУУЛАХ 1. нялахын үйлдүүлэх хэв; 2. няалгадах.

НЯЛУУН 1. чихэртэйютэр мөртлөө аягүй; *нялуун амт; чихрийг хоолны шөлөнд хийчихсэн нь муухай нялуун амттай болжээ; нялуун үнэр;* 2. ш и л ж с э н үг дагаж бялдуучилсан; бялдуучлан наалдсан нь; *нялуун зан; нялуун үг; нялуунаас шулуун нь дээр* з ү й р.

НЯЛУУРАХ нялуун болох, нялуун зан гаргах.

НЯЛХ 1. төрөөд удаагүй, сая төрсөн нь; *нялх төл; нялх хүүхэд;* **нялх нойтон, нялх балчир** х о р ш.; **нялхын халуун** (нярайлсан эхэд тусах нэгэн зүйлийн хүнд өвчин); **нялх бие** (сая нярайлсан бие); 2. сая ургаж байгаа, сая цухуйсан нь; *нялх ногоо; 3.* ш и л ж с э н эрт, бага, залуу; *нялх бага насандаа; нялх залуу үе.*

НЯЛХАМСАГ нялх мэт ааль зантай; *нялхамсаг хүүхэд.*

НЯЛХАМСАГЛАХ нялхамсаг байдал гаргах, нялхамсах.

НЯЛХАМСАХ нялхамсаг зан гаргах.

НЯЛХАС нялх, олон нялх.

НЯЛХРАХ нялх болох; **бие нялхрах** (тамирдаж нэн яданги рах).

НЯЛХРУУЛАХ нялхрахын үйлдүүлэх хэв.

НЯЛЦАЙЛГАХ нялцайхын үйлдүүлэх хэв.

НЯЛЦАЙХ нялцгай нялцгар болох; *гурил нялцайх;* **бие нялцайх** (биеийн байдал суларч ядрах).

НЯЛЦАЛЗАХ нялцгар, нялцгай юмны нялцас нялцас хийх; *шавар нялцалзах; тоглон гүйж явтал хөл дор нэг юм нялцалзсаныг үзвэл нэг мэлхий байжээ.*

НЯЛЦАЛЗУУЛАХ нялцалзахын үйлдүүлэх хэв.

НЯЛЦГАЙ 1. нялцгар, өтгөн биш, шингэвтэр; *нялцгай зуурсан гурил; нялцгай шавар;* **нялцгай биетэн** (нуруугүй, дотроо ясгүй, гаднаасаа дунгаар бүрхэгдсэн байдаг амьтан); 2. бие махбод туйлын жижигхэн, дорой; *мигуйн сая төрсөн улаан нялцгай зулзага.*

НЯЛЦГАЙДАХ хэтэрхий нялцгай болох.

НЯЛЦГАЙДУУЛАХ нялцгайдахын үйлдүүлэх хэв.

НЯЛЦГАЙЛАХ нялцгай болгох.

НЯЛЦГАЙРАХ улам нялцгай болох.

НЯЛЦГАНАХ нялцгар юмны нялцга нялцга хийх.

НЯЛЦГАНУУЛАХ нялцганахын үйлдүүлэх хэв.

НЯЛЦГАР 1. нялцгай, шингэвтэр; 2. бие дорой, сул; *нялцгар биетэй хүүхэд.*

НЯЛЦГАРДАХ хэтэрхий нялцгар болох.

НЯМ I долоо хоногийн долдугаар өдөр; *ням буюу бүтэн сайн өдөр.*

НЯМ II наран гараг.

НЯМБА I у р г а м а л гөлгөн томоо модонд төстэй, нүцгэн ховлын навчтай адил навчтай, хонгорцогт модны цэцэгтэй адил шар цэцэгтэй нэгэн зүйл мод.

НЯМБА II: **нямба хийх** ш а ш и н шашны ёсны бясалгал хийх.

НЯМБАЙ хичээнгүй, нягт; **нягт нямбай** х о р ш.; *нямбай хүн; нямбай айл; ажилд нямбай.*

НЯМБАЙДАХ хэтэрхий нямбай болох.

НЯМБАЙЛАХ нямбай болох, нямбай зан байдал гаргах.

НЯМБАЙРАХ нямбай байдалтай болох.

НЯМДАН у р г а м а л навч бяцхан болоод нарийн, судал нягт хатуу, уул завт ургадаг нэгэн зүйл мод.

НЯМНУУН 1. ус баахан тачир, зулбан, нимгэн, нявталган; *нямнуун арьс; нямнуун үстэй;* 2. тарга хүч нимгэн, туранхи. турхан; *нямнуун хүчтэй морь; хүч тарга нямнуун.*

НЯН анх төрмөл бичил махбод, гагцхүү бичил дуранд үзэгдэнэ.

НЯНТАХ нянтай болох, нян тогтох.

НЯНЦДАХ няслах; *магнай дээр нь нянцдах.*

НЯНЦДУУЛАХ нянцдахын үйлдүүлэх хэв, *няслуулах.*

НЯРАВ эд хогшил, хөрөнгө зөөрийн эрхлэгч сан хадгалагч; *барааны нярав; мөнгөний нярав.*

НЯРАВТАХ бусдын юмыг нярав мэт эзэмших.

НЯРАВТУУЛАХ няравтахын үйлдүүлэх хэв

НЯРАЙ нялх, шинэ; **нялх нялзрай, нялх нярай** х о р ш.; *нярай хүүхэд; нярай бие* (сая төрөөд байгаа нялх бие); **нярай мах** (яр шархны доторхи хөрсгүй мах).

НЯРАЙЛАХ хүүхэд гаргах, хөнгөжих; **нярайлсан эх** (хүүхдээ гаргачихаад байгаа эх); **нярайлах эх** (хүүхдээ гаргахыг завдан байгаа эх).

НЯРАЙЛУУЛАХ нярайлахын үйлдүүлэх хэв, төрүүлэх, хөнгөжүүлэх.

НЯРВААН буддын шашны ёсонд гаслангаас тонилох, орчлонгоос тонилох, үхэх, мөхөх; **нярваан болох, нярваан дүр үзүүлэх** (үхэх).

НЯРДХИЙХ нирхийн дуугарах чимээ; *ширээ нярдхийж дуугарав; лав гэмтсэн байх.*

НЯРХИЙХ нэгэн зүйл чимээ; *пир нярхийх чимээ гарав.*

НЯС: тас няс хийх нэгэн зүйл чимээ; *буугийн дуу тас няс хийв.*

НЯСАЛГАА няслах үйлийн нэр; *нясалгаа сайтай нясалгаа муутай.*

НЯСВААНЯС буддын шашны ёсонд гаслангийн уг шалтгаан, орчлонгийн хүлээс.

НЯСЛАГАА нясалгаа.

НЯСЛАГДАХ няслахын үйлдэгдэх хэв.

НЯСЛАХ 1. гарын хуруунуудыг хооронд нь гоҳдох, ачих мэтээр тээглүүлэн тийргэж чавхдан дэлдэх; *бөгцэг няслах; духан дээр нь няслах;* 2. хумсны завсарт хавчуулан бяцлах; *толгой няслах;* 3. бусдыг бяцхан зовоох.

НЯСЛУУЛАХ 1. няслахын үйлдүүлэх хэв; 2. няслагдах .

НЯСУУ яр, түүхий.

НЯСУУН гашуу: **гашуун нясуун** х о р ш.

НЯСУУРАХ нясуудах.

НЯСУУТАХ нясуу гарах.

НЯСЧИХ байн байн, дахин дахин няслах.

НЯТЛАХ алах, нядлах; **алах нятлах** х о р ш.; *мал нятлах газар.*

НЯТЛУУЛАХ нятлахын үйлдүүлэх хэв, нядлуулах.

НЯЦ хүч нэмэгдүүлэх үг; *няц цохих; няц дарах;* ☆ **хөх няц болох** (няцран хөх өнгөтэй болох).

НЯЦААЛГА няцаах үйлийн нэр, буцаалга.

НЯЦААЛТ няцаах үйлийн нэр, буцаалт.

НЯЦААХ няцахад хүргүүлэх, буцаах.

НЯЦАЛТ няцах үйлийн нэр, буцалт.

НЯЦАРХАЙ няцарсан, бяцарсан, бяцархай, няцарч хэмхэрсэн, бутарсан нь; *няцархай ташуур.*

НЯЦАХ буцах; **буцах няцах** х о р ш.; *ам няцах; зориг тангариг няцах.*

НЯЦАШГҮЙ буцашгүй, буцаж болшгүй.

НЯЦЛАГДАХ няцлахын үйлдэгдэх хэв.

НЯЦЛАХ хэмхэх, няцруулах, жижигрүүлэх, талхлах, бутруулах; *жамсний ясыг бахиар няцлав.*

НЯЦЛУУЛАХ 1. няцлахын үйлдүүлэх хэв; 2. няцлагдах.

НЯЦРАХ 1. үйрч хэмхрэх, бутрах, бяцрах, няцархай болох; *шүдэнзний хайрцгийн дээрээс гишгэж орхисон нь няцарчихлаа;* 2. юманд нухагдаж цохигдон арьсан дотор цус хурж хөхрөх; 3. ш и л ж с э н агсгадаж бие хөндүүрлэх; *ноғоо тарих ажил хийсэндээ хамаг бие няцарчихжээ.*

НЯЦУУЛАХ няцахын үйлдүүлэх хэв, няцахад хүргүүлэх.

НЯЦЧИХ 1. олон юмыг улбас болгон хэмхлэх, бутлах, бяцлах; *энэ яснуудыг няцчих хэрэгтэй!* 2. бутран хэмхрэх; *тамхины хайрцаг өвөрт явсаар няцчижээ.*

НЯЦЧУУЛАХ 1. няцчихын үйлдүүлэх хэв; 2. няцлагдах, няцчигдах.

О

О о авиа, о эгшиг.

ОАЗИС цөл говь газрын ургамал ус бүхий зурвас.

ОБЛИГАЦИ улсын зээллэгийн тэмдэгт, билет; *облигацийн дугаар; облигацийн хонжвор.*

ОБСЕРВАТОРИ одон орон, цаг уурыг шинжлэх шинжилгээний газар; *обсерватори байгуулах.*

ОБЪЕКТ биднээс үл шалтгаалан ухамсраас хараат биш орших гадаад ертөнц, үнэн байдал.

ОБЪЕКТИВ I бодит; *объектив үнэн.*

ОБЪЕКТИВ II гэрэлтлэг багажийн өмнөх шил.

ОВ I заль, арга мэх, уран бааш; *ов гаргах;* **ов жив, ов мэх** х о р ш.; **овын амьтан** (ов мэхтэй амьтан); **овт довтлогоо** (морин дээр зүйл бүрээр маяглаж довтлон наадах).

ОВ II: **ов тов** энд тэнд, цөөвтөр, бага сага; *ов тов цоохор; ов тов цастай газар.*

ОВ III хүч нэмэгдүүлэх үг; *ов ойрхон; ов ондоо.*

ОВ IV: **ов шувуу** гуйванга шувууны өөр нэр.

ОВГОНОХ овгор юмны овго овго хөдлөх; *хураалгатай өвсөн дор нэг юм овгонож байгааг үзвэл мал байжээ.*

ОВГОНУУЛАХ овгонохын үйлдүүлэх хэв.

ОВГОР товгор, товойж гарсан нь; *овгор шороо;* **овгор товгор** х о р ш..

ОВГҮЙ самбаагүй, мэхгүй, ов муутай; *ясан овгүй хүүхэд вэ.*

ОВЪЁС у р г а м а л хавар тарьж, зун буюу намар хурааж авдаг ургамал, үрээр нь мал тэжээхэд сайн; *моринд овъёс өх; овъёсны түрүү.*

ОВЪЁСЛОХ малд овьёс идүүлэх; *морио овъёслох хэрэгтэй.*

ОВЪЁСЛУУЛАХ овёъслохын үйлдүүлэх хэв.

ОВЖИГНОХ овжин зан гаргах.

ОВЖИН самбаа сайтай, залирхуу; *овжин хүүхэд.*

ОВЖИНДОХ хэтэрхий овжин болох.

ОВЖИНТОХ овжин байдал гаргах.

ОВЖИРХОГ овжин байдалтай, залирхаг байдалтай.

ОВЖИРХОХ овжин байдал гаргах.

ОВЖИРХУУ овжин зантай, залирхуу.

ОВИЛГО төрх, байдал; *овилго нь олддоггүй хэцүү хүн.*

ОВИЛГОГҮЙ заан зан тогтууригүй, төвбиш; *овилгогүй амьтан.*

ОВИЛГОГҮЙДЭХ хэтэрхий овилгогүй болох.

ОВИЛГОГҮЙТЭХ овилгогүй зан байдал гаргах.

ОВИЛГО овилго.

ОВЛИГОГҮЙ овилгогүй.

ОВЛИГОГҮЙДЭХ овилгогүйдэх.

ОВЛИГОГҮЙТЭХ овилгогүйтэх.

ОВЛОГ овтой, сэргэлэн, залирхуу, залирхаг; *овлог хүү; овлог амьтан.*

ОВЛОГДОХ овлохын үйлдэгдэх хэв, мэхлэгдэх, хууртагдах, залилагдах.

ОВЛОХ ов гаргах, залилах, мэхлэх, хуурах.

ОВЛУУЛАХ I. овлохын үйлдүүлэх хэв, мэхлүүлэх, залилуулах, 2. овлогдох.

ОВНО амьтан тарс гэдэг шувууны эрэгчин, шувуу барьж иднэ.

ОВОГ 1. ясан төрлийн удам угсааны үеүламжилсан нэр, омог; *Хатгин овгийн нүүдэлчин;* **овгийн байгуулал** (нэгэн удам угсаанаас үүсвэртэй, цусан төрлийн холбоотой бүлэг хүмүүс, энэ нь хүй нэгдлийн байгууллын эх үүсвэр болно); 2. өөрийн нэрд хавсаргасан эцгийн нэр; *овог Бат; нэр Чулуун. овог нэрээ бичих.*

ОВОГЛОХ овгий нь дагалдуулан нэрлэх, овгий нь хэрэглэх; *хойт эцгээрээ овоглох.*

ОВОГЛУУЛАХ овоглохын үйлдүүлэх хэв.

ОВОЙЛГОХ овойхын үйлдүүлэх хэв, овгор болгох.

ОВОЙЛГУУЛАХ овойлгохын үйлдүүлэх хэв, овгор болгуулах.

ОВОЙХ овгор болох; *мөс овойж хөлдөв;* **овойх товойх** хорш.

ОВОЛЗОХ 1. овгор юмны овс овс хөдлөх; 2. шилжсэн хүн амьтны нэг газарт үлэмж хэн олноор хурж үймэлдэх; *олон хүн оволзож байна.*

ОВОЛЗУУЛАХ оволзохын үйлдүүлэх хэв.

ОВОО I 1. овоолж босгосон, цогцолсон юм; *хоёр овоо аргал; гурван овоо цас;* 2. уул даваан дээр овоолж босгосон чулуу; *Монгол газар даваа бүрийн орой дээр овоо байдаг; овоо тахих;* **уул овоо** хорш.; *овоо босгох;* **ясан овоо босгох** шилжсэн (хүн амьтныг үй олноор хядаж ясыг овоолох); **хилийн овоо** (хилийн тэмдэг); **махан овоо хийх** шилжсэн (хүүхдийн дүрсгүйтэн нэг нэгнийхээ дээрээс олноор овоорох); *овоо босгоогүй бол шаазгай хаанаас суух вэ* зүйр. • •

ОВОО II бууны гол төмрийн үзүүрийн дээд талд байх шагааж тааруулдаг жижиг шовгор; *бууны овоо; овоо харааг тааруулах.*

ОВОО III нохой үнэг мэтийн амьтны гавлын дээрх хэсэг газар; *нохойг овоо дээрээс нь шүүрэн базаж авлаа.*

ОВОО IV бузгай, нилээд сайн, зэгсэн; *унахад овоо морь; овоо сурдаг хүүхэд; овоо юм олов; овоо л доо!*

ОВООДОЙ 1. лам нарын хурал номын үйлд өмсөх ирмэгтэй, хавчиг өндөр оройтой, үстэй буюу хилэн малгай; 2. хуучирсан лам ноёдын малгайн хүндэтгэл:

ОВООДОХ амьтны овоо дээрээс нь барих, шүүрэх; *Дугар баатар гэгч барсыг овоодож аваад өвдөг дороо хийж орхижээ* (домог).

ОВООЛЛОГО 1. өргөн сууртай шувтан шовгор оройтой цогцолон хийсэн барилга; *Мисирийн овооллого;* 2. бие бие дээрээ дам гарч овооролдон хийх биеийн тамирын нэг зүйл; *сурагчид овооллого хийж үзүүлэв.*

ОВООЛОГДОХ овоолохын үйлдэгдэх хэв.

ОВООЛОЛДОХ овоолохын үйлдэлдэх хэв.

ОВООЛОХ 1. юмыг нэг газарт бөөгнөрүүлэн дээр дээрээс давхцуулан цогцлох; *шороо овоолох; цас овоолох;* 2. ш и л ж с э н давхцуулах, үлэмж нэмэгдүүлэх; *бүх ажлыг ганц хүн дээр овоолжээ.*

ОВООЛУУЛАХ 1. овоолохын үйлдүүлэх хэв; 2. овоологдох.

ОВООРОЛДОХ олноор овоорох

ОВООРОЛДУУЛАХ овоорохын үйлдүүлэх хэв.

ОВООРОХ I 1. нэг газарт шаваралдан багшрах; *газар унагасан чихэр дээр шоргоолж овооров;* 2. ш и л ж с э н давхцах, үлэмж хуралдах.

ОВООРОХ II анхаарах.

ОВООРУУЛАХ овоорохын үйлдүүлэх хэв.

ОВООХОЙ 1. унь шургааг мэтээр цамхаг босгож гадуур нь үйс, өвс, исгий, арьс зэргээр хучиж хийсэн хүн суух оромж; цээжин гэр ч гэдэг; *холтсон овоохой; өвсөн овоохой; оторчны овоохой дотор маш дулаан байв; мангасын гэр гэж тэнгэрт тулсан хар овоохой байжээ* (үлгэрээс); 2. олиггүй муу гэр, орон; *маний муу овоохойд хэн ч тоож орохгүй биз.*

ОВООХОН зэгсэн, ихээхэн.

ОВОР 1. бараа, үзэгдэх гадаад байдал; *овор ихтэй ачаа; овор багатай тээвэр;* 2. хөгшин, нас ахимаг дүр царай; *овор ихтэй; залуу оортой;* **овор шинж** (овор дүр).

ОВОРЖИХ хөгшрөх байдалтай болох.

ОВОРЖУУ овор их, оортой, хөгшин дүр царайтай нь.

ОВОРЖУУЛАХ оворжихын үйлдүүлэх хэв.

ОВОРХИЙЛОХ I хүний хэлэлцэхэд ёворхийлох.

ОВОРХИЙЛОХ II морь малын ухасхийж дүрэлхийлэх.

ОВОРХИЙЛУУЛАХ оворхийлохын үйлдүүлэх хэв.

ОВОРХОГ сэхээ самбаа сайтай, юмны эе эвийг олохдоо ухаалаг сэргэлэн, залирхаг; *тэр чинь сурхий оворхог хүн дээ.*

ОВОРХОХ оворхог байдал гаргах.

ОВОРХУУ оворхог, овжин, залирхаг залирхуу.

ОВРОХ анзааран ажиглах, болгоомжлох, ухаарах.

ОВРУУЛАХ оврохын үйлдүүлэх хэв, ухаарууллах.

ОВС I. ов мэх, самбаа заль; 2. **илбэ, ховс.**

ОВСЛОХ овс гаргах.

ОВСХИЙХ гэнэт овос хийх, хөдлөх; *толгой нь овосхийн гарч ирэв.*

ОВТ ов ихтэй, заль ихтэй; *овт шар үнэг;* **овт довтлогоо.**

ОВТОЙ ов мэхтэй, зальтай; *овтой амьтан.*

ОВУУНА а м ь т а н алаг тогшуурга гэдэг шувуу.

ОВХГОНОХ овхгор юмны овхго овхгө хөдлөх.

ОВХГОНУУЛАХ овхгонохын үйлдүүлэх хэв.

ОВХГОР 1. хэвийн жишээнээс өндөрхөн, дэвсгэр суурьаар хөдлөх ганхах байдалтай юм; *овхгор хад чулуу;* 2. хамрын болцгор том; *овхгор хамар.*

ОВХОЙЛГОХ овхойхын үйлдүүлэх хэв, овхгор болгох.

ОВХОЙХ овхгор болох.

ОВХОЛЗОХ овхгор юмны овхос овхос хөдлөх.

ОВХОЛЗУУЛАХ овхолзохын үйлдүүлэх хэв.

ОВЦОГ: овцог товцог хэсэг хэсэг овгор.

ОГДГОНОХ огдгор юмны огдго огдго хөдлөх.

ОГДГОР хэвийн жишээнээс богино, охор, оготор, оодон; *огдгор дээл; огдгор сүүл.*

ОГДОЙ сүүл охор оготнуудын ерөнхий нэр; *үхэр огдой.*

ОГДОЙЛГОХ огдойхын үйлдүүлэх хэв, огдгор болгох.

ОГДОЙХ огдгор болох.

ОГДОЛЗОХ огдгор юмны огдос огдос хөдлөх.

ОГДОЛЗУУЛАХ огдолзохын үйлдүүлэх хэв,

ОГЗОМ 1. богино охор юм; *огзом биетэй амьтан;* 2. зан дээрэнгүй, түргэн, охор богино бодлоготой; *огзом зантай; огзом бодлоготой.*

ОГЗОМДОХ хэтэрхий огзом болох.

ОГЗОМЛОХ огзом зан байдал гаргах.

ОГЗОМХОН баахан огзом.

ОГИУЛАХ огихын үйлдүүлэх хэв.

ОГИХ 1. дээш цоройн булт, мулт үсрэх; дээш харван цойлдох, дээш түрэн гарах; *хүүхэд өлгийгөөсөө огиж гарав*; 2. хий бөөлжих, бөөлжихийг завдан бөөлжис гарахгүй хоосон бөөлжих мэт хөдөлгөөн гаргах; *муухай юм хараад золтой л огичихсонгүй; хий огих.*

ОГЛО хүч нэмэгдүүлэх үг, ховх; **огло татах** (юмны өнгийг хэсэгхэн газар ховх татах; *дээлийн өнгийг хадаасанд огло татжээ; хумсаа огло татах);* **огло цохих** (цохиж ховх татах); **огло үсрэх** (а. оглорох; *миний дээлийн ташаа огло үсэрч орхижээ;* б. гэнэт давхийн харайх; *огло үсэрч босон харайгаад тэр чигээрээ гүйж гарав);* **огло харайх** (гэнэт давхин зайлах; *унаж явсан морь нь гэнэт огло харайв).*

ОГЛОЛОХ оглоруулах.

ОГЛОРОХ юмны хэсэгхэн газар огло үсрэн шалбарах, ховхрох.

ОГЛОРУУЛАХ оглорохын үйлдүүлэх хэв.

ОГЛОЧИХ байн байн оглолох.

ОГНИУД өвөр Монголын нэгэн аймгийн нэр.

ОГНОГОНОХ огногор юмны огного огного хөдлөх

ОГНОГОР цогногор, цавчим өндөр юм; *огногор хамар; огногор хад.*

ОГНОЙХ огногор болох.

ОГНОЛЗОХ огногор юмны огнос огнос хөдлөх.

ОГОО 1. огт, ер, цорын огоот, *огоо танихгүй хүн; огоо үзээгүй сонсоогүй юм;* 2. маш; *огоо сайн.*

ОГООРОГДОГСОД орхигдогсод, хаягдагсад.

ОГООРОГДОХ орхигдох, хаягдах, мартагдах, огоорохын үйлдэгдэх хэв.

ОГООРОХ 1. хаях, гээх, мартах, орхих; 2. шилжсэн тэвчих, орхих, болих; *хэлснээ огоорох; архи тамхийг огоорох гэж сэтгэв.*

ОГООРУУЛАХ 1. огоорохын үйлдүүлэх хэв; 2. огоорогдох.

ОГООТ огт, ер, огоо; *огоот больё; огоот мэдэхгүй.*

ОГОТНО 1. үхэр огдой; 2. хулгана, шовх хоншоортой, сахалтай, урт сүүлтэй бяцхан мэрэгч амьтан; **оготно хулгана** хор ш.; *оготно мэрж буртагласан идээ; оготнын нүх; оготнын ноохой; оготно мэт хэдэр, хэрээ мэт хэргүүлч* зүйр.

ОГОТОР 1. богинохон болсон, тайрсан, тасалсан, хугарсан, богино болсон нь; *оготор сүүл; хотгор дотор оготор оготно* (хэл зүгшрүүлэх үг); 2. богинохон, тагдгар; *оготор хамартай; олон үгэнд олзгүй, оготор нохойд шинжгүй* зүйр.

ОГОТОРДОХ хэтэрхий оготор болох; *дээл оготордоод өмсч болохгүй болов.*

ОГОТОРДУУЛАХ оготордохын үйлдүүлэх хэв.

ОГОТОРЛОХ оготор болгох.

ОГОТОРЛУУЛАХ оготорлохын үйлдүүлэх хэв.

ОГСГОНОХ огсгор юмны огсго огсго хөдлөх.

ОГСГОР огдгор.

ОГСОЙЛГОХ огсойхын үйлдүүлэх хэв, огсгор болгох.

ОГСОЙХ огсгор болох, огдойх.

ОГСОЛЗОХ огсгор юмны огсос огсос хөдлөх.

ОГСОЛЗУУЛАХ огсолзохын үйлдүүлэх хэв.

ОГТ бүр, хэрхэвч, ер; *огт мэдэхгүй; огт байхгүй; огт биш; огт болохгүй; огт хэрэггүй.*

ОГТЛОГДОХ огтлохын үйлдэгдэх хэв.

ОГТЛОДОС огтолсон юм; *огтлодос мод; дээлийн огтлодос.*

ОГТЛОХ 1. хэрчиж таслах; *хутгаар огтлох; мах огтлох; мод огтлох; гар огтлох;* 2. шилжсэн юмыг хөндлөн тийш туулан одох, зорчих; *зам огтлох; амьг хөндлөн огтолж гарав.*

ОГТЛУУЛАХ 1. огтлохын үйлдүүлэх хэв; 2. огтлогдох.

ОГТОРГУЙ 1. огт торох юмгүй, газрын дээр байгаа хүнхэр зай мэт хөндий агаар; тэнгэр ч гэдэг; *оторгуйн уудам; оторгуйг эзэмших; оторгуйн хязгааргүй;* **огторгуйн оёдол** (тэнгэрийн оёдол); **огторгуйн төв** (агаарын дунд); **огторгуйн нисгэгч** (тусгай хөлөг онгоцоор огторгуйд нисэгч; *оторгуйн нисгэгч Ю.Гагарин*); 2. бинтийн ёгт нэр.

ОГТОРХОЙ: огторхой тавих шавдал авах, хоёр хуруугаар хүний бугуйг жанчих.

ОГТОС огц.

ОГТРОО 1. жалга, **сархиат ихтэй бэл хажуу** газар; 2. ш и л ж с э н өнгө, **нэхий дээлийн** дундуур залгасан зүйдэл; *дээлийн огтроо;* 3. ш и л ж с э н будлиан самуурал; *огтроотой хэрэг;* 4. ш и л ж с э н гажуу зан авир; *огтроотой хүн.*

ОГТРООЛОХ 1. огтроо бүхий газраар явах; 2. ш и л ж с э н дээлд огтроо залгах.

ОГТРОХ баахан баахан тэвшисхийх

ОГТХОН огт, бүр; *огтхон ч хийж болохгүй; огтхон ч бүү чингээрэй.*

ОГТЧИХ олон дахин буюу хэсэг хэсэг болгож огтлох.

ОГТЧУУЛАХ огтчихын үйлдүүлэх хэв.

ОГЦ 1. эрс, огзом; **огц эчих** (эрс хугарах, тасрах); 2. сочмог, гэнт, санамсаргүй.

ОГЦОМ 1. огзом, охор, богино, **эгц, цавчим**; *огцом эргэх; огцом огтлох;* 2. ш и л ж с э н охор, богино; *огцом бодлого;* **огцом зантай** (ууртай, ширүүн); ☆ **огцом эгшиг** (богино эгшиг).

ОГЦОМДОХ хэтэрхий огцом, богино болох; *гогцоо нь огцомдоод болохгүй байна.*

ОГЦОМЛОХ огцом бодлогоор аашлах, оморхож түргэн зан гаргах.

ОГЦРОХ I эрхэлсэн албан тушаалаас хасагдан гарах; *тушаалаас огцрох; албанаас огцрох.*

ОГЦРОХ II огц эчих, тасрах, хугарах.

ОГЦРУУЛАХ огцрох I-ийн үйлдүүлэх хэв.

ОГШИГДОХ огшихын үйлдэгдэх хэв.

ОГШИХ 1. өөд хөөрөх, өргөгдөх, дээшээ болох; **хормой огших** (дээлийн хормой өөдөө гадагш эргэх); 2. сунаж дээш гарах; *шүд огших;* 3. мэс хуйгаас аяндаа сугарах; *сэлэм огших;* 4. огшуурах.

ОГШУУЛАХ огшихын үйлдүүлэх хэв, огшиход хүргүүлэх.

ОГШУУРАХ бөөлжихийг завдан үе үе дотор муухай болох, дур болих.

ОГЬСОХ хуурай огшуулах, хий огих.

ОД (ОН) 1. огторгуйд цэг мэт гэрэлтэн үзэгдэх тэнгэрийн эрхэс; **одон гараг** х о р ш.; **одон бодис зүй** (огторгуйн од гаргийн бүтсэн, тогтсон байдал хийгээд түүний хими физикийн чанар чадлын тухай шинжлэх ухаан); **од судлал** (одон гаргийг судлах ухаан); **од судлалч** (од судлалд мэрэгжсэн хүн); **одон орныг судлах оргил** (тэнгэрийн байдал, нар, сар, од гаргийг байнга шинжлэн үзэхэд зориулан төхөөрсөн багаж хэрэгсэл бүхий тусгай газар); **одны дуран** (одон гаргийг шинжлэн үзэхэд хэрэглэхээр тусгайлан үйлдсэн дуран авай); **од жарвалзах** (одны гэрэл хөдлөх); **од түгэх** (харанхуй болж од үлэмжхэн үзэгдэх); **од сийрэх** (үүр цайж огторгуйд түгсэн одны зарим нь үзэгдэхгүй болж цөөрөх); **од нягт** (одон маш үлэмж); **од жирэв жирэв болох** (гэрээ орж одон сийрэг болох); **одон харвах** (од унах); **од унах** (чулуу мэтийн хатуу бодис нэгэн газраас тасарч унан, гүйх хүчиндээ хөндий агаарт хавиран халж гал ноцон гүйж үзэгдэх); **од зарах** (од унах); **одны гэр** (одны орших газар); 2. жинлүүр, чинлүүрийн нуруун дахь жин лангийн тоог заасан тэмдэг; *дэнсний од; жингийн од;* 3. торгонд саагаар гаргасан толбо цоохор; *одтой торго;* 4. ямар нэгэн юман дахь одон мэт гялалзах өчүүхэн цэгүүд; *чулууны од; ундаргын од;* 5. бууны овоо; **од овоо** х о р ш.; 6. х у у ч и р с а н авын үзүүр; *авын од;* 7. аз, цог, заль; *одтой хүн; од нь онгойжээ; од нь цоорчээ.*

ОДЕЯЛ хөнжил.

ОДЛОХ юманд од гаргах; *чинлүүрийн модыг одлох.*

ОДОЙ хэвийн жишээнээс богино жижиг, давжаа; *одой хүн;* **одой шүд** (хажууд ургасан шүд); **одой тахиа** а м ь т а н (**хөл** охор нэг зүйл тахиа).

ОДОН гавьяа байгуулахад шагнах тусгай ялгах тэмдэг; *хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон; алтан гадас одонгоор шагнагдав; одонгийн үнэмлэх; одонгийн лент.*

ОДОНТ одон тэмдэг бүхий; *алтан гадас одонт.*

ОДОНЧУУ нарийн цэмбэ; *одончуу дээл; улаан одончуугаар бүтээсэн ширээ.*

ОДОО 1. эдүгээ, энэ үе тохиолдож байгаа цаг; *одоо цаг; одоо болтол; би одоо завгүй байна; одоогоос завдахгүй бол болохгүй; одоогийн залуучууд; одоогийн хүмүүс;* **одоо дээр** (маш яарах, нүдний өмнөх); 2. тун удахгүй, даруй; *би одоо очлоо; одоо та хүлээх хэрэгтэй болжээ.*

ОДООХОН тун одоо, тун даруй; *та нар одоохон яваад ирэх хэрэгтэй.*

ОДООХЬ энэ үе дахь, энэ тохиолдол дахь.

ОДОХ байсан газраас зорчин явах; *Баатар ийн өгүүлээд цааш одов; хун шувуу тэндээс нисэн одов.*

ОДТОЙ 1. од бүхий юм; *одтой тэнгэрт нэг гэрэл явсаар байв; одтой торго;* 2. азтай, золтой; *чи энэ жил одтой байна шүү даа, тэргүүлэх магадгүй.*

ОДУУЛАХ одохын үйлдүүлэх хэв, явуулах.

ОЁГ 1. хашин; *оёг морь;* 2. далд өвчин, гэм, согог; *оёг суух; оёг олох.*

ОЁГДОХ оёхын үйлдэгдэх хэв.

ОЁГЛОХ 1. хашигнах; 2. оёг гэм олох.

ОЁГЛУУЛАХ оёглохын үйлдүүлэх хэв, оёг олгох.

ОЁГОР: оёгор соёгор оёо соёо.

ОЁДОЛ 1. оёх үйлийн нэр; *оёдлын бүлгэм; оёдлын машин;* 2. юмны оёсон газар нь, оёо, оёос; *оёдлоор ханзрах;* **оёдол нийлүүлэх** (торго бөсний зэрэг юмны хоёр хэсгийг нэг газарт хавсран оёх шаглах); ☆ **тэнгэрийн оёдол** (тэнгэрт цайран үзэгдэх олон од хурсан зурвас).

ОЁДОЛЧИН оёх мэрэгжилтэй хүн; *бид оёдөлчноор дээл хийлгэв.*

ОЁМОЛ оёж хийсэн нь; *оёмол хөрөг.*

ОЁС I: **оёо соёо** өндөр нам, урт богинотой; *оёо соёо ургасан мод.*

ОЁО II амьтан далайн нэг зүйл загас.

ОЁО III оёдол, оёос.

ОЁОДОХ соёодох, гогодох; *оонын эврээр оёодоод, олон ноёдоор дамжуулаад...* (оньсго).

ОЁОР ёроол; *хувингийн оёор.*

ОЁОРЛОХ ёроол хийх.

ОЁОРЛУУЛАХ оёорлохын үйлдүүлэх хэв.

ОЁОС оёо, оёдол; *оёосоороо ханзрах.*

ОЁУЛАХ оёхын үйлдүүлэх хэв;

ОЁХ эд бөс, арьс зэргийг зүүгээр сүлбэн утас оруулж бэхлэх; *хувцас оёх; машинаар оёх.*

ОЗООР ёзоор, бөгс; *уурганы озоор; модны озоор.*

ОЗОХ хөхөн шимж үнсэх, амаар таалах.

ОЗУУЛАХ озохын үйлдүүлэх хэв.

ОЙ (Н) I мод бүрхмэл ургасан хэсэг газар; *ой дотор явах; ойн зах;* **ойн анги** (ойн хэргийг эрхлэх газар); **ойн цагдаа** (ой модыг сэргийлэн харах цагдаа); **ой газар** (уул хээр дахь маш их мод игч ургаж, нар тавтайяа үзэгдэхгүй газар); **ой мод** (уул хөдөөд ургасан их мод); **ой цэцэрлэг** (ургамал, мод элбэг болоод устай, цэцэг навч дэлгэрсэн газар); **ойн аж ахуй** (ой мод үржүүлэх тухай ухаан); **ойн үхэр бөөрөлзгөнө** ургамал (навч шаравтархан, иш сойхын адил, богино, жимс үхэр бөөрөлзгөнөтэй адил); *ой модны дунд урттай богинотой, олон хүний дунд сайнтай муутай* зүйр.

ОЙ (Н) II бүтэн өдөр хоног жил болох хугацаа; *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дөчин жилийн ойн их баяр; А. С. Пушкиний нас нөгчсөний зуун жилийн ойг тэмдэглэв;* **ойндоо хүрсэн хүүхэд** (нэг нас хүрсэн хүүхэд).

ОЙ III оюун, ухвар; **ой сайтай** (тогтоох, цээжлэхдээ сайн); **ойнд орох** (ухаанд бодогдон ирэх); **ойнд багтахгүй** (ухагдахгүй); **ой тойнд орох** (а. сайн ухаарагдах; б. санаанд тавтайяа нийлэлцэх); *ойд ормоор, олонд сонсогдмоор* зүйр.

ОЙ IV жигших, зэвүүрхэх, тэсвэр; **ой муутай (хялбар жигших, зэвүүрхэх); ой сайтай**

(а. ухаан сайтай; б. барагтай бол жигших зэвүүцэхийг мэддэггүй); **ой гутах** (муухай юмыг үзэх, амтлах, үнэрлэх зэрэгт дургүй хүрч бөөлжис хутгалах мэт болох).

ОЙВОРГОН 1. хэргийн үзүүрээр сүр бадран мөчид хөдөлдөг; *ойворгон хүн;* 2 зусар зулгайч.

ОЙГҮЙ I модгүй газар; *ойгүй нүцгэн уул.*

ОЙГҮЙ II хэтэрхий ой муутай.

ОЙГҮЙ III оюун ухаан муу.

ОЙГҮЙ IV зүйрлэшгүй; *ойгүй сайхан эд; ойгүй муухай айл.*

ОЙЛГО юм анхныхаа зүг чигийг өөрчлөх, хугарал; *гэрлийн ойлго; ойлгын өнцөг.*

ОЙЛГОЛТ ойлгох үйлийн нэр, ойлгох явц, ойлгоц; *таны хэлсэн зүйл над эргэлзээх ойлголт төрүүлэв.*

ОЙЛГОМЖ утга учры нь ухах чанар; *ойлгомж сайтай.*

ОЙЛГОМЖГҮЙ учир утга нь тодорхой биш бөгөөд ухаарахад бэрхшээлтэй.

ОЙЛГОМЖТОЙ учир утга тодорхой, ухахад хялбар.

ОЙЛГОХ I ухах, учрыг ухамсарлан мэдэх; *та нар ойлгож байна уу? би ингэж ойлгов; учрыг ойлгох;* **ойлгох ухах** х о р ш.. .

ОЙЛГОХ II 1. ойхын үйлдүүлэх хэв; *энэ бөмбөгийг дээш нь ойлго;* 2. ш и л ж с э н юмыг хэтрүүлэх; *ойлгох зантай хүн; аягүй л бол ойлгосон байж мэднэ.*

ОЙЛГОЦ ойлгомж, ойлголт; *ойлгоц муутай.*

ОЙЛГУУЛАХ ойлгохын үйлдүүлэх хэв.

ОЙЛГУУР юмыг хэтрүүлэн ярих зантай; *ойлгуур хүн.*

ОЙЛЛОГО ямар нэгэн юмны тухай тусгайлан тодорхойлсон тэмдэглэл бичиг; *газар нутгийн ойллого.*

ОЙЛОГ ой ихтэй, ойгоор баялаг.

ОЙЛОХ I ухаж мэдэх, ухах.

ОЙЛОХ II олон дахин ойх.

ОЙЛУУЛАХ ойлохын үйлдүүлэх хэв.

ОЙЛХИЙЛЭХ 1. байн байн ойх; 2. дэвхцэн харайлах.

ОЙМ I у р г а м а л бор сойх шиг том бөгөөд гүн салаалсан навчтай спор бүхий ургамал.

ОЙМ (ОН) II бүхэл модыг ухаж хийсэн хамар шуумгай, хойтох нь тэгш бяцхан завь; **оймон бялзуухай** (уран шувуу).

ОЙМС хөлд гутлын дотуур өмсөх хувцасны зүйл; *даавуу оймс; торгон оймс; исгий оймс;* **оймс цоолдох** (оймсны цоорсон элэгдсэн газрыг нөхөх); **оймсны хараа** (оймсны тусгай эмжээр, бас оймсны гутлын түрийгээс дээш гарсан хэсэг); **оймс элээх** (юм үзэж өнгөрүүлэх; *чамайг бодвол би хэдэн оймс илүү элээсэн хүн).*

ОЙР 1. хол гэдэгтэй эсэргүүцэлдсэн утга, алс биш, зайтай биш, дөт, хол биш, холгүй; *ойр газар; ойр очих; энэ талаар нь явахад ойр; ойр суух;* **ойр зуур** (асар холгүй; *ойр зуурын аянд явна; ойр зуурын хүнтэй уулзана);* 2. төрөл ургийн холбоо хол биш; *ойр төрлийн хүн;* 3. ш и л ж с э н зөрүү багатай, ойролцоо, ялгаа багатай; *эх зурагтайгаа ойр байна;* 4. төдий удахгүй, даруйхан шиг; *ойрын өдрүүдэд; ойрын жилд; ойрын ирээдүй; ойрын зам.*

ОЙРД ойн ард, Монголын нэгэн овогтны нэр, дотроо: Дөрвөд, Хойд, хошид, Цорс гэдэг дөрвөн ялгавар бий;*дөрвөн Ойрд; ойрдын аймгууд; ойрдын аялгуу.*

ОЙРДОО саядаа, ойрын хэд хоногт; *ойрдоо хүр орсонгүй; ойрдоо би тэднийд очсонгүй.*

ОЙРДОХ хэтэрхий ойр болох; *чи бид хоёр арай ойрдоод байна, жаахан холхон суу я.*

ОЙРДУУЛАХ ойрдохын үйлдүүлэх хэв.

ОЙРМОГ саявтар, саяхан; *би хотод ойрмог ирсэн, ойрмог танилцсан хүн.*

ОЙРНООС саянаас, ойрын үеэс; *ойрноос хулан элбэг үзэгдэх болов; ойрноос бороо оромтгой болж байна.*

ОЙРОВТОР 1. нилээд ойр; *манай гэр ойровтор бий;* 2. саявтар; *би ойровтор ирэв.*

ОЙРОЛЦОО 1. нилээд ойр, асар холгүй; *манай адуу ойролцоо бий;* 2. саявтар; *би ойролцоо ирэв;* 3. адилавтар; *энэ хоёр хүүхдийн нуруу ойролцоо юм.*

ОЙРТГОХ улам ойр болгох.

ОЙРТОХ улам ойр болох, дөтлөх, шахамдах; *манайх ойртож ирнэ; цаг ойртож байна; дуусах ойртов.*

ОЙРТУУЛАХ ойртохын үйлдүүлэх хэв.

ОЙРХИ ойрын, хавийн; *ойрхи айлууддаа мэдэгдэх; аль ойрхи дэлгүүрт очих.*

ОЙРХОГ ой мод ихтэй.

ОЙРХОН баахан ойр.

ОЙРХУУ ойрхог.

ОЙС өвчүүний доод хувийн дундах яс.

ОЙТ ой бүхий, ойтой; *ойт хээрийн бүс.*

ОЙТОЙ I ой мод ихтэй; *ойтой газраар явах хэцүү.*

ОЙТОЙ II 1. юмыг ойлгох ухах, ухаан сайтай; *ойтой сурагч;* 2. жигшим зэвүүцэм юмнаас жигшиж гутахыг мэддэггүй.

ОЙХ 1. юм юман дээр тусч дээш дэгдэх; *дээш өшиглөсөн бөмбөг газар буумагц ойж өвдөө хөөрөв;* ☆ **цус ойх** (нүдний цагаан дотор цус хурах); 2. овойж хөлдөх; *ус ойж хөлдөв;* 3. шилжсэн хүн орон нутгаасаа буюу мал адгуус ижил сүргээсээ зайлан явах.

ОЙЧИХ 1. унах; *мориноос ойчих; ширээ дээрээс ойчив;* **муурч ойчих** (ухаан алдах); 2. барилдаж дийлэгдэх; *улсын заанд ойчив.*

ОЙЧУУЛАХ ойчихын үйлдүүлэх хэв.

ОЙШООГДОХ ойшоохын үйлдэгдэх хэв.

ОЙШООЛГОХ ойшоохын үйлдүүлэх хэв, ойшооход хүргүүлэх.

ОЙШООХ тоомсорлох, тааламжлан үзэх, зөвшөөрөх; *ойшоож үзвэл зохих зүйл; нилээд ойшоосон байдалтай байв.*

ОЙШООХГҮЙ тоомсорлохгүй, тааламжлахгүй; *хүний сануулан хэлснийг ойшоохгүй байдаг нь буруу.*

ОЙШООЛТОЙ ойшоовол-зохих, ойшоомоор.

ОКОП бууны сумнаас халхлан ухсан нүх.

ОКТЯБРЬ 1. аравдугаар сар; 2. аравдугаар сарын хувьсгал; *Октябрийн баяр; Октябрийн хувьсгалын нөлөө.*

ОЛБИ 1. амьтан ойн бяцхан мэрэгчин, урд хойт хөлийн хооронд нимгэн арьсан далбаатай, модонд дамжин ниснэ; *олби оготно;* 2. шилжсэн ов жив ихтэй, шаламгай; *олби шиг хүүхэд.*

ОЛБОГ суух дөрвөлжин дэвсгэр, исгийг цэмбэ торго мэтээр өнгөлж тусгай дотор хийж үйлдэнэ; *олбог тавих; олбог дэвсгэр; олбог цоортол суусан мэргэнээс, олныг тойрсон мунхаг дээр зүйр.*

ОЛБОГО амьтан сагам загасны яаруурын цагаан загас, цагаан загас ч гэнэ, **авлаж** ашиглана.

ОЛБОР 1. үнэгүй ашиглан хэрэглэх **зүйл; олз олбор, олбор толбор** хөрш.; ☆ **олбор хүү** (өргөмөл хүү); **олбор ядах** (нүүр **үзэж өршөөн** санах); 2. булш, онгон, хот **балгадын** туйраас олдсон эд агуурс олдвор ч гэдэг; *Хар Хорин хотоос гарсан олборын зүйл.*

ОЛБОРИХ 1. санаа сэтгэл **урвах; 2. ухиран** хувисах; 3. хөмрөх, онхолдох.

ОЛГОЙ хүн ба адгуус амьтны бүдүүн гэдэсний шувтрах хэсэг; ☆ **мухар олгой** (хүний олгойн мухрын дээр байх дотроо битүү, нарийн, бяцхан унжлага); **олгой хорхой** амьтан (говьд оршдог, олгой мэт хэлбэртэй, маш хортой хорхой гэж хүмүүс ярилцдаг, **түүнийг** үзэж шинжилсэн зүйлгүй).

ОЛГОЙДОХ шингэн зүйлийн харван гарах, цоргих, оргин цутгах; *усаар олгойдох.*

ОЛГОЙДУУЛАХ олгойдохын үйлдүүлэх хэв.

ОЛГОХ олгохын үйлдүүлэх хэв, олоход хүрүүлэх, өгөх; *цалин олгох; эрх олгох; баримт олгох; шагнал олгох; нөхөн олгох; тусламж олгох; тавьж олгох.*

ОЛГУУЛАХ олгохын үйлдүүлэх хэв, олгоход хүргүүлэх.

ОЛДОЙ болхи, дорой, **хөдхө**; *олдой хийцтэй эд; олдой хүн.*

ОЛДОХ I 1. эрмэлзсэн, алдсан зэрэг **зүйл** тохиолдох, илрэх; *эрсэн юм нь олджээ;* 2. **ойлгогдох**, ухагдах, мэдэгдэх, илрэх; *арга нь олдох; учир нь олдох;* 3. хуучирсан **өршөөн** хүмүүжүүлэх; **олдон засах** (өршөөн засах, илбэн засах); **олдвол ёсоор болгохыг эрнэ** (гуйх байдал).

ОЛДОХ II хэтэрхий олон болох; *үзэг олдоод алиар нь бичихээ мэдэхгүй болжээ; үг олдож, үхэр холдох* з ү й р.

ОЛДОШГҮЙ олдоход бэрх, маш ховорхон юм; *олдошгүй ховор эрдэнэ.*

ОЛДУУРИЛАХ арвилан хэрэглэх, **хэмнэлт**тэй хэрэглэх.

ОЛЖГО олгойн хажууд байх илүү эрхтэн.

ОЛЗ (ОН) үнэ өртөггүй олсон юм; **олз омог, олз ашиг** х о р ш.; *олз ч үгүй, гарз ч үгүй; олзны бага нь ашигтай* з ү й р; *олзны юмыг олуулаа* з ү й р; **олзны цэрэг** (дайсан этгээдээс баригдсан цэрэг).

ОЛЗЛОГДОХ олзлохын үйлдэгдэх хэв; *олзлогдсон цэрэг; дайсан этгээд манай цэрэгт олзлогдов.*

ОЛЗЛОХ олз болгох; *дайсны хаяж зугадсан үлэмжхэн тооны буу зэвсгийг олзлон авчээ.*

ОЛЗЛУУЛАХ олзлохын үйлдүүлэх хэв.

ОЛИГ I 1. үлгэн салган өвчин, биед дагтаршсан эмгэг; *олиг олсон амьтан;* 2. үг өгүүлэл солиг саармаг; **олиг солиг** х о р ш..

ОЛИГ II: **олиг муутай муу, дорой, чадваргүй;** *олиг муутай явдал болжээ.*

ОЛИГГҮЙ сайн биш, муу; *олиггүй амьтан; олиггүй эд.*

ОЛИГДОХ олихын үйлдэгдэх хэв.

ОЛИГОР нүд сөлөр бөгөөд өндөр ёйхгор.

ОЛИГТОЙ овоо, зэгсэн, зүгээр, сайн; *олигтой үзэг байхгүй; хичээл олигтой давтахгүй байна; олигтой юм байна уу?*

ОЛИГТОЙХОН нилээд олигтой; *олигтойхон шаардах хэрэгтэй; олигтойхон мориор явна.*

ОЛИГТОХ олиг өвчин тохиолдох.

ОЛИЙЛГОХ олийхын үйлдүүлэх хэв.

ОЛИЙХ I олигор болох; *оньсго хэлбэл олийсон сохор болно; үлгэр хэлбэл өлийсөн сохор болно* (шог үг).

ОЛИЙХ II замаас муруйн одох; *чигээрээ явж байснаа гэнэт баруун тийш олийж явлаа.*

ОЛИМПИАД биеийн тамир урлагийн тэмцээн; *олон улсын олимпиад.*

ОЛИУ: олиу солиу 1. хөндлөн гулд, өндөр нам, урт богино, урд хойно зэргээр тэгшгүй нь; *олиу эвэртэй үхэр;* 2. олиг солиг.

ОЛИУЛАХ олихын үйлдүүлэх хэв.

ОЛИФ маажин, маалингын тос.

ОЛИФДОХ маажиндах, олиф тос түрхэх.

ОЛИФДУУЛАХ олифдохын үйлдүүлэх хэв, маажиндуулах.

ОЛИХ 1. үзүүртэй багаж юмны үзүүрээр өргөж хаях; *саврын үзүүрээр олих;* 2. үхрийн зэрэг мал эврээр сэжин дээш хаях; *хар бух хурааллтай өвсийг эврээрээ ольж хаялав.*

ОЛМОСИ у р г а м а л 1. нэг зүйл өвсний нэр; 2. мөн өвсний үр, үрийг эмнэлэгт хэрэглэнэ.

ОЛНОО олон гэдэг үгний оршихын тийн ялгалын хэлбэр, олонд; *Олноо өргөгдсөний арван нэгдүгээр он;* **Олноогийн арван нэгдүгээр он** (нэг мянга есөн зуун хорин нэгдүгээр он).

ОЛОГНОХ юмыг дундуур нь бүслүүрдэх; *авдраа ологнож бэхлээрэй.*

ОЛОЙР морины олмыг хэтэрхий чанга татаж арьсы нь гэмтээснээс тогтох зурвас цагаан ус; *олойртой хар морь.*

ОЛОЙРОХ олойртох.

ОЛОЙРТОХ олойр гарах.

ОЛОЙРТУУЛАХ олойртохын үйлдүүлэх хэв.

ОЛОЙРУУЛАХ олойртуулах; *хул алаг морийг сур олонгоор олойртуулахаас өөр ямар олонгоор олойртуулах вэ* (хэл зүгшрүүлэх үг).

ОЛОЛТ олох үйлийн нэр; **ололт амжилт** х о р ш..

ОЛОМ I гол мөрний гаталж болох гүйхэн газар; *Орхон голыг олмоор нь гатлав.*

ОЛОМ II морины гэдсэн доогуур оруулан авчирч горхинд нь жирмийг оруулан татаж тогтоох голдуу хялгас томж хийх оосор; *олмоо татах.*

ОЛОМГҮЙ I хөлгүй, маш гүнзгий, хөлөөр туулан гаталж үл болох; *оломгүй газраар мориор гарч болохгүй гол;* **оломгүй далай** (а. хөлгүй их ус; б. орчлон).

ОЛОМГҮЙ II олом байхгүй; *миний эмээлд жирэмтэй атлаа оломгүй байна.*

ОЛОМЛОХ сур, дээсийг олмын горхид оруулан хэлээр нь торгох.

ОЛОМТОЙ I олом бүхий юм; *оломтой гол.*

ОЛОМТОЙ II оломлох юмтай; *эмээл л юм бол оломтой байх хэрэгтэй.*

ОЛОН цөөн гэдэгтэй эсэргүүцэлдсэн утга, тоо үлэмж, их; *олон хонь; олон давхар; олны олон таван цэн з ү й р; олонтой бол баян з ү й р; олон ирвэл цайгүй, орой ирвэл зайгүй з ү й р;* **олон цөөн** х о р ш.; **олон үг** (хэрэгтэй, хэрэггүй илүү үг); **олон зан, олон ааш** (хувирамтгай зан ааш); **олон жил** (удаан жил); **олны өмнө** (нийтийн өмнө); **олонд алдарших** (нийтийн дунд нэр цууриатах); **олны тус** (нийтийн тус); **олны итгэл** (нийтийн итгэл); **олон ярих** (дахин дахин ярих); **олон дахих** (байн байн үйлдэх): **олон юм үзэх** (жаргал зовлон, сайн муу зүйл бүрийн их юм үзэж өнгөрүүлэх); **олон өнгөт** (янз бүрийн өнгөтэй); **олон ирж очих** (байн байн ирж очих); **олон улсын** (а. үлэмжхэн улсад хамаарагдах; *олон улсын ажилчны хөдөлгөөний нэрт зүтгэлтэн;* б. гадаад гүрнүүдийн; *олон улсын байдлын тойм);* **олон нийтийн байгууллага** (сайн дурын байгууллага); **олон нийт явуулах** (а. олон нийтийн байгууллагаас ажил зохиох; б. олноороо цугларан наргиан цэнгэл хийх); **олон түмний дунд** (олон нийтийн дотор); **олон түмний ажил** (нийтийн дотор зохион явуулах хүмүүжлийн ажил); **олноороо** (бүгдээрээ, хэсэг бүлгээрээ, хамтаараа): **олон нийт, олон түмэн** (нийт ард олон); **олон гишүүнт** (хэд хэдэн нэг гишүүнтийн нийлбэр буюу ялгавар); **олон өнцөгт** (бүтүү шугамаар холбосон, дөрвөөс дээш өнцөг бүхий хэмжих ухааны бие); **олон цамцаалт** (олон талт); **олон талт** (хэд хэдэн тал бүхий хэмжих ухааны бие); **олон гоо** (а. ганц биш үлэмж, үлэмжээр байх; б. ганц биш, үлэмж юмыг заах дагавартай үг); **олон таван үг** (дэмий үг, илүү үг; *чи бүгий олон таван үг яриад бай);* **олон яс нийлэх** (ууцны яс, хоёр сүүжтэй нийлсэн уулзар газар).

ОЛОН II олом; *эмээлийн олон.*

ОЛОНГОДОЙ цавинд хүрсэн урт **түрийтэй** гутал.

ОЛОНДОЙ онондой хүрэм.

ОЛОНТАА олон дахин, олон удаа, их л олон, нилээд буюу ихэд; *олонтаа тохиолдоно; ном уншиж байхыг олонтаа үзэв.*

ОЛОНХИ ихэнх, дийлэнх; *олонхийн саналаар шийдвэрлэв.*

ОЛОНХИДОО ихэнхдээ, дийлэнхдээ.

ОЛОНЦ у р г а м а л хээр ургах нэгэн зүйл ногоо, исгэлэн ус хийнэ.

ОЛОНЦОГ эмээлийн суудалд хийсэн зөөлөвч; *эмээлийн олонцог; олонцгийн цэмбэ.*

ОЛОНЦОР: олонцор сур эмээлийн дээр хэт хадсан сур.

ОЛОНЧУУ олонц.

ОЛОХ 1. харсан эрсний эцэст тохиолдох, илрүүлэх, авах, эдлэх; *олз олох; хээрээс тамхины хайрцаг олов; эрж яваад олох; ашиг олох; эрх мэдэл олох;* **нэр алдар олох** (нэртэй болох); **эрх чөлөөгөө олох** (эрхтэй, чөлөөтэй болох); 2. ойлгох, ухах, мэдэх; **учры нь олох** (а. утга учры нь гарган илрүүлэх; б. нэгэн тийш болгох); *учры нь олж, хужры нь тунгаах* х у у ч.

ОЛС (ОН) у р г а м а л 1. ялмын төрлийн өвсөрхөг ургамал, узуураар нь эдлэл хийнэ; үрээс нь тос авна; 2. мэн ургамлаар хийсэн татлага; **олс дээс** х о р ш.; *олсоор хүлэх; татлагын олс;* **олсон хараацай** а м ь т а н (сэвх бүхий хядран хараацай).

ОЛСГОХ олтгох, олон болгох.

ОЛСОХ олтох, олшрох, олон болох.

ОЛТГОХ олтохын үйлдүүлэх хэв, улам олон болгох, олшруулах.

ОЛТОХ улам олон болох, олшрох, нэмэгдэх.

ОЛТРИГ тэнгэс дахь хэсэг бүлэг ардууд; *цэргийн хөлөг онгоц олтригт ойртон ирлээ.*

ОЛУУЛ ганц нэгээр биш, олноор; *бид гэртээ олуул; олуулаа явахад хөгжөөнтэй.*

ОЛУУЛАХ олохын үйлдүүлэх хэв.

ОЛХИО: олхио муутай олиггүй, **урагшгүй,** бүтэмжгүй; *олхио муутай хүн.*

ОЛХИОГҮЙ олхио муутай; *олхиогүй эд.*

ОЛХИОН: олхион үг дэмий үг, чалчаа үг.

ОЛХИОТОЙ олигтой, бүтэлтэй, урагштай, өөдтэй; *олхиотой явах; олхиотой арьс байхгүй.*

ОЛХИОТОЙХОН нилээд олхиотой, олигтойхон, өөдтэйхөн, урагштайхан, бүтэлтэйхэн; *олхиотойхон ярилцахгүй бол бүтэхгүй; олхиотойхон хүнийг явуулах.*

ОЛХОН нилээд олон; *олхон хүн цугларсан байв.*

ОЛШРОХ улмаар олон болох; *гишүүний тоо олширчээ; нэгдлийн хонь олширсон байлаа.*

ОЛШРУУЛАХ олшрохын үйлдүүлэх хэв.

ОЛЬДОЙ 1. бүдүүлэг, дүйнгэ; *ольдой хүн;* 2. юмны хийц байдал бүдүүлэг, муухай; *ольдой хийцтэй ширээ.*

ОМГО: омго омго хийх омгос омгос хийх.

ОМГОЛДОХ хэтэрхий омголон болох.

ОМГОЛОН амьтны омогтой догшин; *омголон морь; омголон зантай.*

ОМГОЛТОХ уруул хатаж осгортох, давхайж ерийн зөөлөн биш болох; *уруул нь омголтжээ, халуунтай байх шиг байна; салхинд уруул омголтох.*

ОМГОНОХ I юмны ам дотогш татан хөдлөх; *уруул нь омгонон уйлахыг завдав; хөдөс омгонон түлэгдэх.*

ОМГОНОХ II хорхой шавьж мэтийн юм хуниран, татганан хөдлөх.

ОМГОНУУЛАХ омгонохын үйлдүүлэх хэв.

ОМГОР өмгөр, цухал, явцуу, дэндүү бяцхан ам амсартай; **омгор хомгор** х о р ш.: *цай нүдэж болохгүй омгор уур байна.*

ОМГОРХОГ омогдох байдал бухий.

ОМГОРХУУ омгорхог, оморхог.

ОМГОС: омгос омгос хийх омгор юмны омго омго хөдлөх.

ОМОГ I ааг, шар; *омогтой хүн; омог нь шатах; омгий нь дарах;* **омогтой, шартай** х о р ш.; **омог төгөлдөр** (омог бардам); **омог бардам** (өөрийнхөө илүүтэйд бардамнах ааг).

ОМОГ II ирмэгтэй юмны дугуйдуу хяр; *чихний омог; нудраганы омог.*

ОМОГ III овог, үндэс; *ямар омгийн хүн бэ? омгийн байгуулал.*

ОМОГДОГДОХ омогдохын үйлдэгдэх хэв.

ОМОГДОХ омог гаргах, доромжлон загнах, аашлах; *омогдох хэрэггүй, учир зүйгээ ололцон ярилцъя гэв.*

ОМОГДУУЛАХ 1. омогдохын үйлдүүлэх хэв; 2. омогдогдох.

ОМОГЛОХ омогдох, омог гаргах.

ОМОГТОЙ омог бүхий; *омогтой залуу; ямар омогтой хүн бэ.*

ОМОГШИХ омог төрөх, бардам дээрэнгүй болох.

ОМОГШУУЛАХ омогшихын үйлдүүлэх хэв.

ОМОЙХ омгор болох, атирч, хомойж үрчийх; *түлэгдсэн хөдөс шиг омойж орхив; шир хатаад омойж орхив; ам нь омойх.*

ОМОЛГОДОХ дэндүү омолгон болох.

ОМОЛГОН омголон.

ОМОЛЗОХ омгор юмны омс омс хөдлөх байдал.

ОМОЛЗУУЛАХ омолзохын үйлдүүлэх хэв.

ОМООРОХ овоорох.

ОМОРХОГ оморхдог, омог ихтэй; *оморхог бол олны дайсан* з ү й р.

ОМОРХОГЛОХ омогдох, омогтой зан гаргах.

ОМОРХОХ омогдох, хөөрхөх, дээрэнгүйлэх.

ОМРУУ 1. морь малын өвчүү орчны газар; 2. шувууны өвчүү; 3. хүний өнгөлүүрийн хоёр хажуугийн яс; 4. үхрийн хүзүүний дорхи сул арьс; 5. зарим амьтны хоёр суганы өмнө өвчүүний ойсын нийлэлтийн газар ургасан цагаан үс; *баавгайн омруу.*

ОМТГОЙ мөчид, хуумгай; **омтгой мөчид, осол омтгой** х о р ш.; *хэтэрхий омтгой болов уу гэж бодов.*

ОМТГОЙДОХ хуумгайдах, наагуурдах, мөчиддөх, осолдох; *омтгойдож хэрхэвч үл болно.*

ОМТГОЙДУУЛАХ омтгойдохын үйлдүүлэх хэв.

ОМТГОЙЛОХ омтгой санах, үл итгэмжлэх.

ОМТГОЙХОН баахан омтгой, хуумгайхан, наагуурхан, мөчидхөн.

ОМТДОХ юмыг үл онох буюу оновч мөчид мөлтөс болох; *сум омтдох.*

ОМТОГО: омтого санах үл итгэмжлэх.

ОМТГОДОХ хуумгайдах, омтгой болох.

ОН I 1. жилийг дэс дугаарлан тэмдэглэхэд хэрэглэх үг; *нэг мянга есөн зуун хорин нэгэн он; бичиг он сар тавих; төрсөн он; он онд идэшиж олон жилд дассан нутаг, одоогийн шинэ Монголын улаан туг бүрхсэн орон* (Д. Нацагдорж); 2. жил; **он жил** х о р ш.; *шинэ он гармагц..;* **онд орох** (он туулах); **он туулах** (малын үхэлгүй урин дулаан болгох); **он түших** (онд ороход ойртох); **он цаг** (өвөл хаврын хатуу цаг); **он цагт тарган оров уу** (малчдын мэнд солилцох үг).

ОН II: **он тусам** х у у ч и р с а н газрын хол ойрын хэмжээ, харвалга хүрэм газар, дээш өргөн харвасан сумны хүрэм газар; **он тусах** (хаймсах); **он тавих** (шав тавих).

ОНГИ (Н) юмны ишийг углах нүх; *шанаганы онги; хүрзний онги; сумны онги;* **онгин** тамга (дундаа хоосон дүгрэг тамга).

ОНГИЛОГДОХ онгилохын үйлдэгдэх хэв.

ОНГИЛОХ I 1. сэндлэх, ухах; *хүрз зээтүүгээр газрыг онгилон ухав;* 2. урж навтруулах; 3. ш и л ж с э н ёроолд хүртэл уудлах, эрэх; *түрийвчээ онгилох; авдраа онгилох.*

ОНГИЛОХ II онги хийх, онги гаргах.

ОНГИЛУУЛАХ 1. онгилохын үйлдүүлэх хэв; 2. онгилогдох.

ОНГИРГОН онгироо, хөөргөн, сагсуу; *онгиргон зантай амьтан.*

ОНГИРГОХ онгироход хүргүүлэх; *их онгиргож болохгүй хүн байгаа юм.*

ОНГИРОО хөөргөн, хөвсөргөн, сагсуу; *онгироо эр.*

ОНГИРООДОХ хэтэрхий онгироо болох.

ОНГИРООТОХ онгирох, хөөрөх, сагсуурах, онгироо зан гаргах.

ОНГИРОХ I онгироо, хөөргөн, сагсуу зан гаргах; *биеэ тоож онгирох; хэтэрхий онгирох хэрэггүй.*

ОНГИРОХ II 1. онгилох сэндлэхэд ховхрон сэндийрэх; *хялбар онгирох хөрстэй газар;* 2. урагдах, навтрах.

ОНГИРУУЛАХ онгирохын үйлдүүлэх хэв, онгироход хүргүүлэх.

ОНГИЧИХ 1. байн байн онгилох; **авдраа онгичих** (авдар дотроо их л эрэх); 2. олныг онгилох; *зэрлэг гахай хоншоороороо газрыг онгичин сэндийчиж орхисон байв.*

ОНГИЧУУЛАХ онгичихын үйлдүүлэх хэв.

ОНГО I онгод.

ОНГО II: **онго цонго** онгор цонгор.

ОНГОГ I 1. онгон; 2. эцэг эхдээ онц дотно; *онгог хүүхэд; онгог хурга.*

ОНГОГ II алтан товч.

ОНГОД ш а ш и н бөө нарын буух үед биед нь ирж ордог хий сүг гэгч; **онгод дуудах** (онгодыг урих); **онгод нь орох** (а. бөөлөх; б. ш о о д с о н урьд хийж үйлдэж байснаа **хойно** дахин хийхэд сэтгэл сэргэж хөөрөх).

ОНГОДОХ нүүх, түгж ихсэх; *усархаг байраар бичсэн бичиг онгодох; тос онгодох.*

ОНГОЙЛГОХ онгойхын үйлдүүлэх хэв, онгойход хүргүүлэх.

ОНГОЙЛГУУЛАХ онгойлгохын үйлдүүлэх хэв.

ОНГОЙХ 1. нээгдэх, онгорхой болох; *хаалга онгойх; дэлгүүр онгойх цаг болов; онгойсон том нүх;* 2. эзлэх юм ба хүнгүй, эзэнгүй, ажиллаж байгаа хүнгүй; *онгойж байгаа орон тоо;* 3. ш и л ж с э н арилах, цэлмэх; *бороо онгойх; манан онгойх;* 4. ш и л ж с э н сэтгэл уужрах, тайван болох; *дотор онгойв.*

ОНГОЛЗОХ 1. байн байн онгойх; *салхинд пингийн үүд онголзоод байна;* 2. ш и л ж с э н сархалзах, онгиргон зан гаргах, онгироотох, сагсуурах; *их онголзож байна.*

ОНГОЛЗУУЛАХ онголзохын үйлдүүлэх хэв.

ОНГОЛИУЛАХ онголихын үйлдүүлэх хэв.

ОНГОЛИХ амьсгал давхцах.

ОНГОЛОХ онгон болгох.

ОНГОЛУУЛАХ онголохын үйлдүүлэх хэв.

ОНГОН 1. х у у ч и р с а н нандин, гар хүрээгүй, эмзэг; **онгон тахилга** (эрхэмлэн тахисан хүүр булш зэрэг); **онгон уул** (тахилгат дархан уул); 2. ш и л ж с э н гар хүрээгүй; эмзэг, атар, эмнэг, элмэг; *онгон тарган адуу; эмнэг онгон;* **онгон дэл** (олон жил хяргаагүй дэл); **онгон үс** (залуу хүний цагаан үс); 3. ш и л ж с э н танхи, танхил, эрх; *онгон зантай; онгон омголон;* 4. хичээнгүй, найртай, **элэгсэг,** еелдэг; **элэгсэг онгон** х о р ш..

ОНГООХ гандаах, шарлаах, **өнгийг хувиргах.**

ОНГОР: **онгор цонгор** хотгор гүдгэр, хонхор ёнхор.

ОНГОРОЙ 1. хэтэрхий том нүх сүвтэй; *онгорой хамартай; онгорой домбо;* 2. ш и л ж с э н хөөргөн, онгироо; сагсуу.

ОНГОРОЙТОХ онгорой, хөөргөн, онгироо, сагсуу зан гаргах, онгироотох; *чи битгий онгоройтоод бай!*

ОНГОРХОЙ 1. нээлттэй, онгойсон, задгай; *онгорхой хаалга; цонх нь онгорхой байв; шүүгээний нүд нь онгорхой байна;* 2. цоорхой, урагдаж цоорсон нь; **онгорхой цоорхой** х о р ш.; 3. ш и л ж с э н эзлэх хүнгүй; эзэнгүй, ажиллаж байгаа хүнгүй; *бичээчийн ор онгорхой байна.*

ОНГОРХОЙДОХ хэтэрхий онгорхой болох.

ОНГОСХИЙХ 1. түр бяцхан онгойх, нээгдэх, гэнэт онгойх; *үүд онгосхийв;* 2. түр сэргэх, уужрах, тайвшрах; *дотор онгосхийх.*

ОНГОХ 1. хүн амьтны дотор хатаж мэндүүрэх, ангах; 2. газрын ба ургамлын зүйл өнгө шарлах, исгий мэтийн юмны чийг эгших, завхрах; 3. эд бөсийн өнгө гандаж бууран хувирах; 4. ш и л ж с э н халуурч мэгдүүрэх.

ОНГОЦ I 1. усанд хөвж явах тээврийн хэрэглүүр; галт **онгоц** (уурын хөдөлгүүртэй онгоц); **далбаат онгоц** (далбаат салхинд хийсгэн явах онгоц); **гуя онгоц** (ухмал гуалинг холбож хийсэн онгоц); **шунгадаг онгоц, шумбадаг онгоц** (усан дээгүүр, усан доогуур аль алинд нь явж чаддаг хөлөг онгоц); **онгоцны алмуур** (онгоцны хаюур); **онгоцны зангуу** (онгоцыг зогсооход хэрэглэх төмөр багаж); **онгоцны шураг** (онгоцны дээр босгосон мод); **онгоцны дөр** (онгоцны хөтлөх оосор); **онгоцны сэлбүүр** (онгоц сэлэх урт мод); **онгоцны дарвуул** (онгоцонд өлгөсөн салхи үлээлгэх ваадан); **онгоцны хэтгэ** (онгоцны бөгс); **онгоц тавих** (онгоцыг усанд оруулах); **онгоцны хичиг** (гуя онгоцны холбоо мод); **онгоцны тавилан** (онгоц тавих газар); **онгоц сэлбэх** (онгоц сэлэх); **онгоцны хаюур** (онгоц залах хүрз); **онгоц хаюурдах** (хаюураар онгоц сэлбэх); **онгоцны толгой** (онгоцны өмнөх үзүүр); **онгоц харайх** (нэг онгоцоос нөгөө онгоцод гарах); **онгоцны гэзэг** (усанд тавих онгоцны дээгүүр хөндлөн хүлж тогтоох мод); 2. далавч, жигүүр бүхий нисэх аппарат; *нисэх онгоц; нисэх онгоцны далавч; нисэх онгоцны жолооч; нисэх онгоцны буудал.*

ОНГОЦ II юмыг дотор нь агуулах урт гонзгор хэлбэртэй хэрэгсэл; *сумны онгоц; хүжний онгоц;* 2. малд тэжээл, ус өгөх хэрэгсэл; *худгийн онгоц; өвсийг онгоцонд хийж өгдөг билээ;* **онгоцны дэр** (мал услах онгоцны ивүүр); 3. дотор нь орж бие угаах хэрэгсэл; *онгоцонд орж биеэ угаах.*

ОНГОЦОЧ онгоц хийдэг хүн.

ОНГУУЛАХ онгохын үйлдүүлэх хэв, онгоход хүргүүлэх.

ОНДГОНОХ ондгор юмны ондго ондго хөдлөх.

ОНДГОНУУЛАХ ондгонохын үйлдүүлэх хэв.

ОНДГОР ёмбогор, тонтгор, товгор; **ондгор тонтгор** х о р ш.; *ондгор бөгстэй морь.*

ОНДОЙЛГОХ ондойхын үйлдүүлэх хэв, ондгор болгох.

ОНДОЙХ ондгор болох; *бөгс нь ондойх.*

ОНДОЛЗОХ ондгор юмны ондос ондос хөдлөх.

ОНДОЛЗУУЛАХ ондолзохын үйлдүүлэх хэв.

ОНДОО 1. адил биш; *хуучнаасаа ондоо юм; энэ хоёр хэргийн учир нилээд ондоо;* 2. өөр; *ондоо хэрэг бий юу? ондоо газраас ирэв;* 3. тус тус; *хоёр ондоо суудаг хүмүүс; ондоо ондоо нэгдлийн мал байгаа юм.*

ОНДООЛОХ ондоо болгох, тусгаарлах, өөрчлөх.

ОНДООЛУУЛАХ ондоолохын үйлдүүлэх хэв, ондоо болгуулах.

ОНДООШИХ ондоо шинжтэй болох; **авиаы ондооших** (адил буюу адилавтар шинжтэй авиа ойролцоо орвол нэг нь өөрчлөгдөх).

ОНДООШУУЛАХ ондоошихын үйлдүүлэх хэв.

ОНДРОХ морь малын баахан булгисхийх.

ОНДЧИХ байн байн ондрох.

ОНДЧУУЛАХ ондчихын үйлдүүлэх хэв.

ОНИВ: **онив онив хийх** онигор юмны байн байн онив анивхийх, анивалзах, анилхийлах.

ОНИВОЛЗОХ анивалзах, анилхийлах; *нүдээ оноволзох.*

ОНИВОЛЗУУЛАХ ониволзохын үйлдүүлэх хэв, анивалзуулах.

ОНИВЧ 1. онин дээрээ, эхэндээ, анх үед, сайн, чадамгай, ирмүүн; *онивч ухаантай; онивч хурдан морь;* 2. сониуч.

ОНИВЧХОН 1. онивч зантай; **туи сүрхий онивчхон морь** (их гараатай хурц морь); 2. сониучхан.

ОНИГ: ониг загас амьтан мөргийн нам, ам бяцхан, далавч улбар шар, хагадас их, урт нь гавин см. нэг зүйл загас.

ОНИГОНОХ онигор юмны ониго ониго хөдлөх.

ОНИГОНУУЛАХ онигонохын үйлдүүлэх хэв.

ОНИГОР 1. бяцхан, жийтгэр нүдтэй; *онигор нүдтэй;* 2. бяцхан, явцуу, давчуу, бачуу; *онигор нүх; онигор амсартай.*

ОНИЙЛГОХ онийхын үйлдүүлэх хэв, онигор болгох.

ОНИЙХ 1. онигор, жийтгар болох; *нүд чинь яагаад онийчихоо вэ?* 2. давчуу, явцуу, бачуу, бяцхан болох.

ОНИЛЗОХ 1. онигор юмны байн байн онийх, анивалзах; 2. бүдэг гэрлийн асч унтрах; *тэнгэрийн хаяанд нэг гэрэл ониволзож байна.*

ОНИЛЗУУЛАХ онилзохын үйлдүүлэх хэв, анивалзуулах.

ОНИЛОГДОХ онилохын үйлдэгдэх хэв.

ОНИЛОХ I 1. юманд онь, хоног, ац гаргах; 2. харвахаар сумны онийг нумны хөвчид тээглүүлэх; *харвах гэж сумаа онилтол....*

ОНИЛОХ II хуучирсан өртөө улааны уналга хэрэглэлийг нийлүүлэх ээлж дараа; онь хүлээх.

ОНИЛУУЛАХ 1. онилохын үйлдүүлэх хэв; 2. онилогдох.

ОННИУД огниуд.

ОНОВОР онол, оноо; *оновор сайтай.*

ОНОВЧ I харвуулын сум хийхээр урчуудын хэрэглэх бяцхан хутга.

ОНОВЧ II хэрэг зүйд тохирсон нь; **оновч муутай** (тохирч чадаагүй).

ОНОВЧТОЙ хэрэг зүйд яг тохирсон, үнэхээр тохиромжтой; *оновчтой арга хэмжээ авч байжээ; оновчтой арга явуулгын үр дүн...*

ОНОГ: алдаг оног хааяа хааяа, үе үе; *алдаг оног хичээл хийж байна; цахилгаан гэрэл алдаг оног асч байна.*

ОНОГДОЛ ногдсон юм; *албан журмын оногдол; сүүний оногдол.*

ОНОГДОХ 1. онохын үйлдэгдэх хэв; 2. юманд дайрагдах, өртөгдөх; *давхиж явсан зээр суманд оногдсонгүй дүүлж цойлсоор бараа туруугүй алга болов;* 3. дайралдах, тохиох; *үүнийг гүйцэтгэх үүрэг над оногдов; албан татвар оногдох.*

ОНОГДОШГҮЙ оногдох шинжгүй.

ОНОГДУУЛАХ оногдохын үйлдүүлэх хэв.

ОНОЛ I оновор, оноо.

ОНОЛ II 1. үзэгдэл, баримт ба түүнд нийтийн ашиг тусын тул нөлөөлөх чадлыг тайлбарлах шинжлэх ухааны ерөнхий зарчмыг боловсруулан гаргах практик, туршлагын нэгтгэл болох сургаал; *марксизм-ленинизмийн онол; танин мэдэхийн онол; харьцангуйн онол; онолын тэмцээн; онолын багц хурал;* 2. ямар нэгэн шинжлэх ухааны нэгэн хэсэг буюу тэрчлэн ямар нэг төгс чадварын тухай дүрэм журмын бүрэн цогц; *шатрын онол.*

ОНОЛДОХ I 1. онохын үйлдэлдэх хэв, тохиолдох, тус тус дайралдах, таарах; *голыг шүргүүлахад арааны дотно гадна хоёр этгээдийн нүх онолдож байх хэрэгтэй;* 2. шилжсэн учрах, тохиолдох; 3. таарах, тохирох; *бид хоёрын санаа жигтэй онолджээ.*

ОНОЛДОХ II 1. зөвхөн онол ярих; 2. онол мэддэгээрээ гайхуулах.

ОНОЛДУУЛАХ онолдохын үйлдүүлэх хэв, онолдоход хүргүүлэх.

ОНОЛЧ онолд мэрэгжсэн хүн; *марксизмын онолч.*

ОНОНДОЙ энгэртэй бөгөөд нарийн ханцуйтай охор хүрэм; *онондой хүрэм.*

ОНОН: онон одох арван их сайтар, гучин найман оронтой тоо.

ОНОО онох үйлийн нэр; *харваачийн оноо их бага байх нь дасгал сургуулиас болно; оноо сайтай өдөр.*

ОНОО II 1. барилдах бөх нарын хэн хэнтэй барилдахыг оногдуулан тэмдэглэх данс; *бөхийн оноо хийх; онооны газар;* 2. шилжсэн хувь, заяа, тавилан.

ОНОО III 1. дээл, хүрэм, цамц зэргийн хормойд нийлүүлэн оёлгүй янзалж хагархай ор-

хисон газар; *оноотой дээл; хүрэмний оноо;* 2. уул хэрэмний ирмэг, хярд байх онь, хотгор; 3. адуу ихэд таргалж зоо, хондлойд гарсан ац; *хүрэн морь таргалаад оноо суусан байв;* **оноо заяа** (үхэр, буга, зээр зэргийн амьтны сүүлийн самсаа орчноос хатгуурын доод этгээд хүртлэх яс мах).

ОНООЛОХ оноо гарах.

ОНООХ оноход хүрүүлэх; **онооссон нэр** (нэг төрлийн олон юмны дотроос ялгаж тусгайлан өгсөн нэр).

ОНООЧ 1. оноо хийдэг хүн; 2. онодог хүн.

ОНОХ 1. олж тусах, тусвал зохих газарт тусах, олж тусгах; *дөрвөн сумандаа дөрөв онов; би буудаад үзэхэд сүрхий оноож байлаа; нугасы нь буудсан нь нуруы нь онох* з ү й р; 2. таамаглал, тааварлал оновчтой тохируулах; *яваагүй нь оножээ, бороонд цохиулах байсан байна.*

ОНОЦ 1. онох үйлийн нэр; 2. юманд таарч тохиолдох зүй, арга; *оноц сайтай; оноц муутай.*

ОНОЦОЛДОХ онолдох, тааралдах, тохирох, дайралдах.

ОНОЦОЛДУУЛАХ оноцолдохын үйлдүүлэх хэв, онолдуулах, тааралдуулах.

ОНОЦТОЙ оновчтой, оноц сайтай.

ОНОЧИХ 1. олны онох; 2. нэгний олонтаа онох.

ОНОШ өвчтөнийг шинжилсний үндсэн дээр гаргах өвчний тодорхойлолт; *онош тавих; онош тогтоох; өвчний онош.*

ОНТОЙ малын онд ором, оныг туулж чадахуйц; *миний халзан хурга ямар ч гэсэн онтой доо.*

ОНТУДАХ он тусах.

ОНТУСАМ дээш өргөж харвасан зэвсгийн хүрэм газар.

ОНТУСАХ сум хаймсах.

ОНУУЛАХ онохын үйлдүүлэх хэв.

ОНХ I тонгорцоглож үзүүр талаараа зогссон шагаа; *онх босох;* **онох дарах** (буу дарах).

ОНХ II: **онх цонх онгор цонгор.**

ОНХГОР 1. ганцаар өндөр том юм; *онхгор хад;* 2. гүн гүнзгий хонхортой; *онхгор аяга.*

ОНХИ огт, ерөөс; *онхийн шинэ.*

ОНХЛИХ онхолдох.

ОНХОЛ I: **онхол бялзуухай** а м ь т а н самрын цөм иддэг нэг зүйл бялзуухай, булга зэрэг амьтан хуш модонд авирвал самрын боргоцойг харамлаж дуугарна.

ОНХОЛ II: **онхол цонхол, онхол тонхол** хонхор цонхор, хонхор хотгор.

ОНХОЛДОХ хөлбөрөх, хөлбөрөн унах, хөмрөх, тонгорцоглох; *тэрэг онхолдох; сандалтайгаа хамт онхолдож ойчив.*

ОНХОЛДУУЛАХ онхолдохын үйлдүүлэх хэв.

ОНХОР хонхор ёнхор, хонхор хотгор.

ОНХОЙХ онхгор болох.

ОНЦ 1. маш, нэн, туйлын, гойд, маш сайн; *манай охин онц дүнтэй шалгагдав; онц хүчтэй шар; онц хурдан морь; онц зүтгэлтэй ажилтан; „Таван онц"-ын тэмдэгтэй сурагч;* 2. бүрэн төгс, чухал; *онц бүрэн эрхт элчин сайд; онц их хурал; гадаад худалдааны онц эрхийг улсын гарт авах.*

ОНЦГОЙ 1. онц тасархай; *онцгой сайн бүтээл; онцгой гавьяа байгуулах;* 2. ганцаараа, тасархай, олноос буйд; *баруун этгээдэд нь онцгой нэг гэр байв; онцгой буух* (буйд хол буух).

ОНЦГОЙДОХ хэтэрхий онцгой болох.

ОНЦГОЙДУУ салангидуу, ганцаардуу.

ОНЦГОЙДУУЛАХ онцгойдохын үйлдүүлэх хэв.

ОНЦГОЙДУУХАН нилээд онцгой, баахан онцгой.

ОНЦГОЙЛОХ онцгой болгон үзэх, онцлон үзэх; *онцгойлон нэрийг цохож хэлэв; онцгойлж үзэх.*

ОНЦГОЙЛУУЛАХ онцгойлохын үйлдүүлэх хэв.

ОНЦГОЙРОХ онцгой болох, онц болох, тасархай болох; *ганцаараа онцгойрон явж байв.*

ОНЦГОЙРУУЛАХ онцгойрохын үйлдүүлэх хэв.

ОНЦДОХ хэтэрхий онц болох.

ОНЦЛОГ онц болгон үзэлтэй юм, өвөрмөц; *өвөрмөц онцлог; онцлог зүйл мөн; монгол морины онцлог.*

ОНЦЛОХ онц болох, тасархай болох; *сургуульдаа онцолж явсан сурагч; чамайг онцолж үзэв; олны дотроос онцлох.*

ОНЦЛУУЛАХ онцлохын үйлдүүлэх хэв.

ОНЧ I оноц, ноц; аньстай газар, **ончий нь олох** (нарийн эв зүйгий нь олох).

ОНЧ II утасны эрчид тунасан, атирсан газар.

ОНЧ III оновч; *онч сайтай; онч муутай.*

ОНЧДОХ 1. ончрох; 2. харвуулын сумны муруй шулууныг тэнсэн эрчийдэх.

ОНЧРОХ 1. нийтгэсэн утас зэргийн нэг эрч нь тунарч үлхийн унжих; *утасны эрч ончрох;* 2. эрч нь хэдийдэн бөөмнөлдөх.

ОНЧТОЙ 1. онч бүхий; 2. оновчтой.

ОНЬ I 1. бяцхан ац, салаа, хоног, юмны ирмэг дээгүүр гаргасан сэтэрхий; *онь гаргах; сумны онь;* **онь им** (малын чихэнд ац гаргасан тэмдэг); 2. уулын хярын сэтэрхий, нахиу, нам хэсэг; онь хөтөл; *уулын оиюр давах.*

ОНЬ (ОНИН) II 1. анх, анхан үе, эхэн үе; *онин дээрээ их л сонирхож байжээ;* **онин дээр** (эхэлсний дараахан, эхэлсний даруйд); 2. эхний, анхны нэгдүгээр; *онь дававнд унав;* **онь даваа** (бөхийн эхний даваа); 3. хуучирсан өртөө уяаны улаа хэрэглэл зүйлийн тохиолдох ээлж дараа; *онь хүлээх.*

ОНЬДОХ юмыг онь бүхий юмаар тулах;

ОНЬС I 1. түгжээ, хаалга мэтийг түгжих хэрэгсэл; *үүдний оньс; модон оньс; оньсоор түгжих;* 2. машин, багаж, аппаратын хөдөлгөх дотоод төхөөрөмж.

ОНЬС II мөн чанар, оновчтой арга; *онъсы нь олох.*

ОНЬСГО таавар, таалга үгс, бусдаар тайлуулах ёгт, битүү утга агуулгатай холбоо үгс; *онъсго таалцах; би нэг онъсго хэлье;* **онъсго худалдах** (онъсгыг эс таавал тогтсон үг хэлж тайлан өгөх).

ОНЬСДОХ юманд онъс хийж торгон тогтоох, бэхлэх.

ОНЬСЛОХ онъсоор торгох, тогтоох; *үүдээ онъслов.*

ОНЬСЛУУЛАХ онъслохын үйлдүүлэх хэв.

ОНЬСТОЙ онъс бүхий юм; **онъстой тоглоом** (онъсон хэрэглүүрээр хөдлөх тоглоом).

ОО I 1. ариун цэврийн зүйлд хэрэглэх сэнгэнэсэн үнэртэй зөөлөн нарийн нунтаг зүйл; *нүүрний оо; оо тавих;* 2. шүд угаахад хэрэглэх ариутгах зүйл; *шүдний оо; нойтон оо;* **оо түрхүүр** (оо түрхэх хэрэгсэл).

ОО II нялх хүүхдийг ямар нэгэн юмнаас жигшээхэд хэрэглэх аялга; *оо, муухай!*

ООДОГНОХ 1. үхэр сарлаг зуны халуунд амь тэмцэн сүүлээ өргөж давхих 2. шилжсэн хүчлагыг хөл талаас сөхөж хуулах, хормой сөхөх; *хормойгий нь оодогнох.*

ООДОГНУУЛАХ оодогнохын үйлдүүлэх хэв

ООДОЙ одой.

ООДОН 1. оготор, богино, богинохон; *оодон сүүл; оодон дээл;* 2. оодогнон явах; *оодонгийн үхэр.*

ООДОНДОХ хэтэрхий оодон болох.

ООДОНТОХ оодогнох.

ООДРОХ хөөрөх, онгирох; *чи дээ бас их оодорч байна даа!*

ООДРУУЛАХ оодрохын үйлдүүлэх хэв.

ООЛЬ нэгэн этгээдэд хөндлөн тийш хандсан иртэй, нөгөө тал дахь онгид модон иш шаасан, өрөөсөн гараар барьж цавчих багаж; *гар ооль; оолиор цавчих; аавын ооль ахих цавчих.*

ООЛЬДОХ оолиор цавчих.

ООЛЬДУУЛАХ оольдохын үйлдүүлэх хэв.

ООНО эр зээр; *оонын эвэр; ооно эвэрдмээр, зээр сүүлдмээр хурдан морь.*

ООР 1. язгуурын, төрөлхийн; оор мэнгэ (а. зарим хүний бие дээр байх алга мэт улаан буюу хар толбо; б. нялх хүүхдийн өгзөг дээр байх, монголын онцгой тэмдэг гэдэг бараан толбо); 2. язгуурын, уулын; **оор Монгол** (Монгол).

ООРЦОГ 1. сондгой, тусгаар ургасан уул овоо, толгой хяр, хад, цохио; *оорцог толгой;* 2. хэсэгхэн, тусгаар; *оорцог хүн; оорцог нохой; оорцог улс.*

ООСОР юмыг уях торгохоор хийсэн бүч, уяа; *ваадангийн оосор; цагны оосор; өрхний оосор; оосор бүчгүй орд цагаан өргөө байв гэнэ* (үлгэрээс); *хүзүүндээ оосортой тугал.*

ООСОРЛОГДОХ оосорлохын үйлдэгдэх хэв.

ООСОРЛОХ оосор уяагаар торгох, уях; *үнээгээ хүзүүгээр нь оосорлон авав; барааны саванг оосорлон дүүжилсэн байв.*

ООСОРЛУУЛАХ оосорлохын үйлдүүлэх хэв.

ООЧ I 1. хүний нахайд ургасан бяцхан сахал; 2. нахай; *оочны сахал.*

ООЧ II балга, ундны зүйлийг чамлах үг; *нэг ооч цай.*

ООЧИН: оочин цоочин хэсэг бусаг, энд тэнд, алаг цоог; *оочин цоочин газар ногоо ургажээ.*

ООЧИХ багаар сорж уух; *халуун цай оочих.*

ООЧЛОХ байн байн оочих.

ООЧЛУУЛАХ оочлохын үйлдүүлэх хэв.

ООЧУУЛАХ оочихын үйлдүүлэх хэв; *дүүдээ жаахан цай оочуулахгүй юү?*

ОПЕР дуулалт жүжиг; *оперын театр.*

ОПЕРАТОР найруулагч, зохицуулагч; *киноны оператор; дууны оператор.*

ОПЕРАЦИ 1. мэс засал; *операци хийх;* 2. ажиллагаа.

ОППОЗИЦ аливаа байгууллага буюу нийгэмлэгийн дотор багтаж, мөнхүү байгууллага буюу нийгэмлэгийн олонхийн эсрэг улс төрийн бодлого явуулагч бүлэг хүмүүс.

ОППОЗИЦИЧ оппозиц бүлгийн гишүүн, оппозиц бүлгийн талын хүн.

ОППОРТУНИЗМ пролетари ангийн эрх ашгийг буржуй нарын ашиг сонирхолд зохицуулах, ажилчин ангийн ашиг сонирхлоос урваж буржуй нартай эвлэрэх улс төрийн бодлого, ийм бодлогыг ажилчин ангийн байгууллагуудад шургалан орсон буржуй нарын төлөөлөгчид явуулна.

ОППОРТУНИСТ оппортунизмийн үзэл санааг баримтлагч.

ОР (ОН) I хэвтэж унтахад зориулсан хогшил; *төмөр ор; модон ор; хүн хагасын ор; хоёр хүний ор; орон дээрээ хэвтэж байв; орны даавуу; орны хэрэглэл;* **орны тоо** (эмнэлэг сувиллын газарт эмчлүүлэх, сувилуулах өвчтөний хэвтэх орны тоо).

ОР II 1. юмны үлдээсэн хэв, байр; *хурууны ор гарах;* **ор сураггүй** (огт мэдээ чимээ, сураг танаггүй; *ор сураггүй алга болох);* 2. үнэний хувьтай; *олны үг ортой оройн бургаас очтой зүйр;* 3. юмны нөхөөс, төлөөс, **төлөө байх** зүйл; *ары нь олох; үгүй болсон юмны чинь ор нь энэ; өвдсөн нөхрийн оронд би ирэв; та нөхрийнхөө орноос ажиллах гэж байна уу?* **ор нэр болгох** (дутуу дулим хийсэн болж ам таглах); **ор нэрийн төдий** (оронцог төдий).

ОР III огт, бүр, нэгмөсөн; *ор тас мэлзэх; ор сураг чимээгүй.*

ОРВОГ сондуул.

ОРВОГОНОХ орвогор юмны орвого орвого хөдлөх.

ОРВОЙЛГОХ орвойхын үйлдүүлэх хэв, орвойход хүргүүлэх.

ОРВОЙХ орвогор болох, өрвийх.

ОРВОЛЗОХ орвогор юмны орвос орвос хөдлөх байдал.

ОРВОН 1. нэг бүхэл үндсээрээ байгаа ургамал, бутаараа байгаа ургамал; *орвонгоор нь суга татах;* 2. үндэс, ёзоор; *үсний орвон.*

ОРВОСХИЙХ өрвөсхийх, сөрвөсхийх.

ОРГАНИЗМ бие махбод, бие; *организмын хөгжил.*

ОРГАНИК 1. шим бодис; **органик химн** (шим хувилахуй ухаан): 2. амьд; **органик холбоотой** (амьд холбоотой).

ОРГИЛ уулын орой, дээд, дээд тал; *өндөр уулын оргилд үүл цас будрахад* (дуу); *одон орны оргил;* **эрдмийн оргил** (эрдмийн дээд).

ОРГИЛОХ 1. оргихын үйлдүүлэх хэв, оргих; 2. үргэлжлэн оргих, олон газар оргих; 3. гэнэт хөдлөх гарах; *ардын бослого оргилон гарав.*

ОРГИЛУУЛАХ оргилохын үйлдүүлэх хэв.

ОРГИЛУУР даралтын хүчинд дээшээ олгойдон гарах шингэн юм; *төв цэцэрлэгийн усан оргилуур.*

ОРГИУЛАХ оргихын үйлдүүлэх хэв.

ОРГИХ I 1. хөөрөн, цоргодон гарах; *цоргоор ус оргин гарч байв; булгийн ус оргиж*

байна; утаа оргих; 2. хүчтэй асгаран буцлах; *тогоотой цай оргиж байна;* 3. ямар нэгэн байдал биед мэдэгдэх, мэдрэгдэх; *халуу оргих; сэрүү оргих; хатуу оргих; эвгүй оргих; эзгүй оргих.*

ОРГОДОЛ оргосон хүн, босгол.

ОРГОЙ бөө нарын тайж урихдаа **өмсөх малгай.**

ОРГОХ босох, буруулан зайлж одох; *дайсны цэргээс оргосон этгээд; гяндангаас оргосон ялтан байжээ; оргон зайлах.*

ОРГУУЛАХ оргохын **үйлдүүлэх** хэв, оргоход хүрүүлэх.

ОРГҮЙ нэгмөсөн, ямар ч мэдэх тэмдэггүй; *оргүй алга болох; оргүй худал хэлжээ. оргүй гүтгэх.*

ОРД (ОН) I 1. хүндэтгэвэл зохих эрхэм хүний байрлан орших орон; *зуны ордон; хааны ордон;* **орд харш** х о р ш.; 2. төрийн эрх барих газрын албан хэрэг явуулах байр; *Засгийн газрын ордон; зөвлөлийн ордон;* 3. нийтээр хуран цугларахад зориулсан томоохон орон байшин; *Залуучуудын ордон; Пионерийн ордон; Биеийн тамирын ордон;* **ордны эргэлт** (хааныг ордны шадар хүмүүс түлхэн унагааж оронд нь өөр хаан суулгах).

ОРД (ОН) II 1. мэхээрийн хулганын идэш хураасан нүх; *хулганын ордыг цоолж мэхээр авдаг байв;* 2. алт, эрдэнийн чулуу зэрэг ашигт малтмалын зүйл гарах нөөц бүхий уурхай; *алтны орд; нүүрсний орд.*

ОРД (ОН) III хэсэг бусаг оддын оршин ахуй газар; *одны орд.*

ОРДЕР аливаа юмыг хүлээн авах, олгох, ашиглахад зориулсан баримт хуудас; *төлбөрийн ордер; орон сууцны ордер; орлого-зарлагын ордер.*

ОРДОС I өвөр монголын нэгэн аймгийн нэр; *ордосын аялгуу.*

ОРДОС II: **ордос алга болох** огт ор мөргүй болох.

ОРДОСЛОХ I ялаар болж байсан өвчин бас дахин өвдөх.

ОРДОСЛОХ II нэгэнт тогтсон хэрэг үйлийг бас дахин цуцлах, халах, өөрчлөх.

ОРДОХ 1. орыг дагах, мөрдөх; 2. ор нэрийн төдий гүйцэтгэх, оромдох.

ОРДОЧ: ордоч бор а м ь т а н бие жижигхэн, бор зүстэй, охор сүүлтэй нэгэн зүйл хулгана, мэхээрийн хулгана ч гэдэг.

ОРИЛОО бархираа, ориломтгой; *орилоо ботго.*

ОРИЛОХ 1. бархирах, чарлах, чанга уйлах; **орилох чарлах** х о р ш.; 2. хашгирах, чанга дуугарах; *ямар их орилох юм бэ!*

ОРИЛУУЛАХ орилохын үйлдүүлэх хэв; *наад хөгжмөө битгий их орилуулаад бай!*

ОРИМОО а м ь т а н гутаар загастай адил загас, далайд оршино.

ОРЛОГО орж байгаа юм; *улсын орлого; мөнгөн орлого, цэвэр орлого; үндэсний орлого; орлого-зарлагын данс;* **орлого зарлага** х о р ш..

ОРЛОГОГҮЙ орох юмгүй, орлого муу.

ОРЛОГОДОХ орлого болгох, орлогод авах.

ОРЛОГОДУУЛАХ орлогодохын үйлдүүлэх хэв, орлого болгуулах, орлогод авахуулах; *үүнийг няравт өгөөд орлогодуулачихгүй юү.*

ОРЛОГЧ 1. ямар нэгэн албан газрын жинхэнэ тэргүүлсэн тушаалын хүний чухам туслах, дэд; *орлогч сайд; орлогч дарга; нэгдүгээр орлогч дарга;* **орлогч гишүүн** (намд жинхлээгүй гишүүн); 2. орлож ажиллагч, орлож гүйцэтгэгч; *сургуулийн захирлыг орлогч Бат гэж бичжээ.*

ОРЛОХ 1. оронд нь байх; *миний өрөөсөн хөлийг суга таяг орлох болов;* 2. хамаарах, төлөөлөх, төлөөнөө байх; *даргыг орлох.*

ОРЛУУЛАХ орлохын үйлдүүлэх хэв, төлөөлүүлэх, хамааруулах, төлөөнөө байлгуулах; захирлыг орлуулах.

ОРОВГОР өрөвгөр; *оровгор үс; оровгор уруултай.*

ОРОГ саарал, зэвхий; *орог саарал;* **орог зусаг** а м ь т а н (хээр, заримдаг цөлийн бүсэд оршдог нэг зүйл хулгана, билчээрт хортой, өвөл ичнэ).

ОРОГДОХ I хэтэрхий орог өнгөтэй болох.

ОРОГДОХ II зүүдэнд юм зөгнөгдөх.

ОРОГНОХ 1. орон байр болгож орох; *өвсөн овоохойд орогнох;* 2. ханьтай нөхцөн айлд суух; *тэднийхээр орогнож явдаг хүн;* 3. нууж хоргодох; *ууланд орогнох; хулгайч нар байшингийн зооринд орогнож байжээ.*

ОРОГНУУЛАХ орогнохын үйлдүүлэх хэв.

ОРОЙ I эртийн эсрэг утга; 1. ямар нэгэн хугацаат үе, цагийн ихэнх нь өнгөрсний дараах эцсийн хэсэг; *намар орой болсон хойно нүүв;* 2. үдэш; *оройн ээлж; өнөө оройн найман цагт; оройн таван цаг болов;* 3. хэвийн хэмжээнээс хожимдох хугацаа; *орой унтвал нэгийг сонсох, эрт босвол нэгийг үзэх* х у у ч.

ОРОЙ II 1. юмны хамгийн дээд этгээд, дээд хувь; *уулын орой; модны орой; малгайн орой; байшингийн орой дээр туг хатгав;* 2. толгойн дээд этгээд; *орой дээр нь тэнгэр тас хийн дуугарав; онгоц яг орой дээгүүр нисэв.*

ОРОЙ III нэг ам бөсийн зүйлийг дөрөв хуваасны нэг; *орой торго; орой хоргой.*

ОРОЙГУУР орой тийш, оройхон.

ОРОЙЛОХ 1. орой хийх; *байшин оройлох;* 2. тэргүүлэх, толгойлох; *бусдыг оройлон явах; оройлон удирдах.*

ОРОЙЛУУЛАХ оройлохын үйлдүүлэх хэв.

ОРОЙТОХ хожимдох; хугацаат үе цагт амжихгүй өнгөргөх; *өнөөдөр оройтов; маргааш эрт явъя; түрүүн хэлэхгүй, одоо оройтож доо; оройтвол эртлэхэд бэрх, доройтвол дэгжээх бэрх* х у у ч.

ОРОЙТУУЛАХ оройтохын үйлдүүлэх хэв; *цагаас оройтуулах.*

ОРОЛДЛОГО ажил хөдөлмөрт санаачлагатай, хичээлтэй, зүгээр суудаггүй, идэвх; *оролдлого сайтай хүүхэд байгаа юм.*

ОРОЛДЛОГОГҮЙ ажил хөдөлмөрт идэвх хичээл зүтгэлгүй.

ОРОЛДЛОГОТОЙ ажил хөдөлмөрт хичээл зүтгэл сайтай; *оролдлоготой сурагч.*

ОРОЛДОО зүгээр сууж чаддаггүй ямагт юм хийж байх дуртай; *юм юманд оролдоотой хүн.*

ОРОЛДООТОЙ оролдоо бий, оролдлоготой.

ОРОЛДОХ 1. орохын үйлдэлдэх хэв; 2. үйлдэлхийлэх, хийх гэж ноцолдох; *цагаа засах гэж оролдож байв; дүгүйгаар оролдох;* 3. чармайх, мэрийх; *сурахын тул их л оролдох хэрэгтэй; олохыг оролдъё;* 4. ш и л ж с э н байн байн гар хүрэх; *хатгиар оролдвол эрхэнэ;* 5. ш и л ж с э н гоочлох, даажигнах; *хүүхдээр битгий оролд! эдээрээ оролдвол эвдэхийн тэмдэг, эхнээрээрээ оролдвол салахын тэмдэг* х у у ч.

ОРОЛДОЦ оролдлого, идэвх, зүтгэл, чармайлт.

ОРОЛДУУЛАХ оролдохын үйлдүүлэх хэв.

ОРОЛТ орох үйлийн нэр, орох үйлийн явц.

ОРОЛЦОГЧ оролцож байгаа этгээд; *уг хэрэгт оролцогчийн нэг бол та мөн юм.*

ОРОЛЦОО 1. оролцох үйлийн нэр; 2. туслалцаа, хамжилцаа; *та бүхний оролцоо байхгүй байсан бол бид энэ ажлыг хийж чадахгүй байсан юм аа.*

ОРОЛЦОХ 1. орохын үйлдэлцэх хэв; *бусдын хамт орох; би оролцъё;* 2. ш и л ж с э н юманд хамтрах, хамааралцах; *олон нийтийн ажилд оролцох; гар бие оролцох;* 3. аливаа үйл явдалд нөлөөлөх, мэдэлцэх; *бусдын хэрэгт оролцох; хөндлөнгөөс оролцох.*

ОРОЛЦУУЛАХ оролцохын үйлдүүлэх хэв.

ОРОМ байсан юмны ор мөр, улбаа; *ором гарах; хурууны ором.*

ОРОМГОЙ орох дуртай, оромтгой, оромхой,

ОРОМДОХ I ор мөр гаргах, ор мөрийг дагах; **оромдоод өөрөмдөх** (улам цаашаа даврах).

ОРОМДОХ II 1. оронцоглох, дөнгөх, хийсэн нэр төдий болох; *ингэж оромдох юм бол хийсний хэрэггүй байна;* 2. бусдад өөрийн биеийг хөнгөмсөглөн өгүүлэхэд хэрэглэнэ; *би л нэг юм оромдогчоо болсон юм.*

ОРОМДУУЛАХ оромдохын үйлдүүлэх хэв.

ОРОМЖ орших орогнох гэр хорго.

ОРОМЖЛОХ орлон хийх, орлох.

ОРОМЛОХ 1. ором ор гаргах; 2. оронцоглох.

ОРОМЛУУЛАХ оромлохын үйлдүүлэх хэв.

ОРОМТГОЙ юманд орох, оролцохдоо дуртай.

ОРОМХОЙ оромгой, оромтгой.

ОРОН I 1. оршин суух газар; улс гүрэн; **улс орон** х о р ш.; *хөдөө аж ахуй-үйлдвэрийн*

орноос, үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болох тухай; хөдөө орон нутагт ажиллах саналаа өгөв; **эх орон** (төрсөн орон; *хайрт Эх орон-Бүгд Найрамдах Монгол Ард Улс мандтугай!*); **орон нутаг** (нэг хэсэг газар нутаг); **орон нутгийн захиргаа** (нэгэн хэсэг газрын захиргаа); *орон бүхний пролетари нар нэгдэгтүн!* 2. нутаг дэвсгэр; *халуун орон; уулархаг орны ургамал.*

ОРОН II орогнон орших, суух газар; **орон байщин, орон сууц, орон гэр** х о р ш.; **орон суурин** (ор суурь); **ор суурь** (а. хот балгад зэрэг байсны буурь, нутаг: б. хуучдын өв хөрөнгө гал голомтыг залгамжилсан айл өрх).

ОРОН III 1. ажилчин, албан хаагчдын орвол зохих тогтоосон тоо; *орон тоог батлах;* **орон гарах** (ажиллах хүнгүй, хоосон болох); **орон тоо** х о р ш.; ☆ **орон, цаг** (материйн оршин тогтохын үндсэн хэлбэр); 2. хүн амьтан буюу юмны төлөөс, нөхөөс; *морины оронд шар өгөв; гээсэн цувны оронд өөр юм өгөх болов; Төмөрхүү байхгүй байна, сугалаагий нь би орноос нь сугалъя.*

ОРОНГИ хойд хөл доголон нь; *оронги татанхай.*

ОРОНГО I а м ь т а н зээртэй адилдуу болоод бяцхан, мушгимал урт бараан өнгийн эвэртэй нэгэн зүйл гөрөөс.

ОРОНГО II дарцаг; *дэлгэсэн оронгот сэрээг дээд доод гартаа барьсан.*

ОРОНЖИХ оронтой болох, суух орон сууцтай болох.

ОРОНЖУУЛАХ оронжихын үйлдүүлэх хэв.

ОРОНЦОГ юмыг голон доршоож өгүүлэхэд хэрэглэх үг; *гэрийн оронцог;* **унааны оронцог** (муу унаа).

ОРОНЦОГЛОХ 1. ор төдий гүйцэтгэх; *хийх гэж оронцоглох;* 2. орыг төлөөлсөн болох.

ОРОНЦОГЛУУЛАХ оронцоглохын үйлдүүлэх хэв.

ОРОНШИХ оршиж байгаа газартаа идээших.

ОРОО I бурууламтгай, баригддаггүй, сүргээс гарч бурууддаг, зугтамтгай; *ороо морийг уургаар, ууртай хүнийг аргаар* з ү й р; **өрөнд ороо** (бусдаас авсан юмаа буцааж өгөхдөө маш хойрго); **ороо нь ороогоороо, жороо нь жороогоороо** (тохирсон таарснаараа нийлэх).

ОРОО II от; *ороо нь орсон буур;* **от ороо** х о р ш..

ОРООГДОХ ороохын үйлдэгдэх хэв.

ОРООДОС ороолт, ороосон юм; *ороодос даавуу.*

ОРООДОСЛОХ 1. тогтоосон хэрэг явдлыг дахин цуцлах, халах, өөрчлөх; 2. эдгэрч байсан өвчин дахиж хүндрэх; *өвчин ороодослох.*

ОРООДОСЛУУЛАХ ороодослохын үйлдүүлэх хэв.

ОРООДОСТОЙ 1. тогтворгүй, итгэмжлэх аргагүй, болзошгүй, хувиламтгай; *ороодостой хүн;* 2. дахилттай; *ороодостой өвчин.*

ОРООЛГОХ 1. ороохын үйлдүүлэх хэв; 2. ороогдох; 3. ш и л ж с э н шавхуурдах, гуядах; *шилбүүрээр ороолгох.*

ОРООЛГУУЛАХ ороолгохын үйлдүүлэх хэв.

ОРООЛДОХ 1. ороохын үйлдэлдэх хэв, бие биеийг ороох, ээдрэх, уяа оосорт ороогдон будлих; *морины хөл аргамжаарааа ороолджээ;* ☆ **гэдэс ороолдох** (гэдэс зангирах); 2. ш и л ж с э н хэрэг төвөгт орох; *гэмт хэрэгт ороолдох;* 3. могойн эр эм хос нийлэх; *модны ёроолд могой ороолдож байв.*

ОРООЛОН 1. буг чөтгөр; *ооно хүрээд ирвэл замын нь заагаад өгье дөө, ороолон хүрээд ирвэл чамайг заагаад өгье дөө* (аман зохиол); 2. маш дүрсгүй.

ОРООЛОХ 1. буруулан зугадах, дутаах; *морь ороолох; орой дээгүүр ороолоод байдаг нь ороо морины зан* (дуу); 2. хүний өр зээлийг өгөхгүй зайлсхийх; *өр өгөхгүй ороолох.*

ОРООЛТ юмыг ороохоод зориулсан зүйл; *барааны оро́олт; хөлийн ороолт; ороолт утас.*

ОРООЛУУЛАХ ороолохын үйлдүүлэх хэв.

ОРООМОГ 1. ороож хийсэн хэсэг юм; *нэг ороомог олс;* 2. малын гэдэс дотрыг алаглан цувуулж нарийн гэдсээр нь ороож хийсэн хоол; *ороомог хийх;* ☆ **ороомог цэцэг** у р г а м а л (өндөр нь хоёр метр илүү, буталж ургана, шинэ салаа ба иш навч өргөстэй, өд мэт хэлбэртэй давхарлаг навчтай, салаанаас гарах цагаан, шар цэцгийн үзүүр давхар хөвөөтэй).

ОРООМОЛ ороож хийсэн юм; **зүү ороомол** (зүү ороож хийсэн).

ОРООНГО зарим сөөг, бут ургамлын урт, уяхан иш, ёзоор; *усан үзмийн ороонго;* **ороонго дэнс** ургамал (ороонго зэлээс бүдүүн том, модонд ороож үргэлжлэн ургадаг, сав суулга сүлжих, ташуурын иш хийх зэрэгт хэрэглэдэг нэгэн зүйл мод; тэнз ч гэдэг); **ороонго зэл** ургамал (нарс, майлс мэтийн модонд зэллэн ороож ургана, гурван хушуутай навч бүхий нэг зүйл мод); **ороонго од** зурхай (бурва бадарбад одны гэрийн хойдод орших ороосон могойн хэлбэртэй хорин хоёр од).

ОРООНГУУ ороонго.

ОРООХ I 1. юмаар тойруулах, тойруулан боох, хучих; *лентээр ороох; сурын үзүүрийг гартаа ороож барив; адгуус амьтны цэцэрлэгт нэг том могой мод ороогоод хэвтэж байв; биеэ дээлээр ороогоод орон дээрээ сууж байлаа;* **тамхи ороох** (тамхи татахад бэлтгэж цаасанд боох); 2. шилжсэн бага хүүхдийн уйлж унжин салж өгөхгүй байх; *хүүхэд нь бүлээрч, эхийгээ ороогоод байв;* 3. шилжсэн асууж хоргоох, эгээгтэй асуулт тавьж гэнэдүүлэх, үг алдуулахыг оролдох; *ороож асуух;* ☆ **зүү ороох** (уран оёдол; *зүү ороосон хавтга бүсэндээ хавчуулжээ*).

ОРООХ II хүнд ачаа ачсан тэмээний хойд хөл нь доголох өвчин олох; *ширээ бөхтэй хүрэн тэмээ ороочжээ.*

ОРООЦОЛДОХ 1. ороохын үйлдэлцэх хэв, ороож эздрэх, хэрэлдэх, ороолдох; *цулбуур моринд хөлд орооцолдвол морь булгиж болно; хөлд орооцолдохоор урт хормойтой дээл;* 2. ямар нэг олиг муутай явдалд нэр бие оролцох; *будлианд орооцолдох.*

ОРООЦОЛДУУЛАХ орооцолдохын үйлдүүлэх хэв.

ОРОС дорнод Славяны ард түмний нэр; *Оросын ард түмний баатарлаг үйл явдал; Орос хэл; Орос хэлний хичээл оров; би нэг орос хүнтэй танилцав.*

ОРОСЖИХ орос маягтай болох.

ОРОСЖУУЛАХ оросжихын үйлдүүлэх хэв.

ОРОСЧЛОХ 1. орос маягтай болгох; 2. орос хэл дээр хөрвүүлэх.

ОРОСЧЛУУЛАХ оросчлохын үйлдүүлэх хэв.

ОРОСШИХ оросын шинжтэй болох.

ОРОХ I 1. аливаа юм, юмны дотор хүрээнд, харьяанд багтах, холбогдох, нийлэх; *гэрт орох; тасалгаанд орох; цонхоор салхи орж байна; ажилд орох; сургуульд орох;* **намд орох** (намын гишүүнд элсэх): **замд орох, замаар орох** (зам дагаж явах, мөрөөр явах; *социализмын замд давшин орлоо; замаар ороод алхав*); **байранд орох, сууцанд орох** (байрлах, байртай болох, сууцанд шилжих; *манайх шинэ байранд оров; одоогоор орон сууцанд орох болоогүй байна);* **бүртгэлд орох** (бүртгэгдэх, бүртгэлд багтах); **дансанд орох** (данслагдах, дансанд багтах); **орлогод орох** (орлогонд багтах, орлогонд тэмдэглэгдэх); **хоолонд орох** (а. хоол идэх; *одоо би яваад хоолонд ороод ирнэ;* б. хоол идэх дуртай болох: *тариа хийлгэснээс хойш тав хоноод хоолонд орж эхлэв);* **гуанзанд орох** (бэлтгэсэн идэш уушны газар хоолллох); **усанд орох** (а. усанд шумбах, угаах; *бид Туул голын усанд оров; халуун усанд тавтай оров; шүршүүрт оров;* б. норох; *усанд орсон тамхи*); **далд орох** (далдлагдан үзэгдэхгүй болох; *нар уулын цаагуур далд оров; морьтой хүн явсаар модон дотор орж далд оров);* **нар орох** (нар жаргах, шингэх); **номд орох** (аливаа сургаалд бишрэх, зөвшөөрөн дагах; *бурүү номтны номд орох);* **шашинд орох** (шашинтай болох, шашинд итгэх; *буддын шашинд орох);* **дагаар орох** (өршөөл, соёлд багтан оролцох); **хүргэн орох** (эхнэрээ дагаж хадмынд орогнох; *айлд хүргэн орж гэнэ);* **хэл аманд орох** (хэрүүл цуугианд нэр багтах, оролцох); **хэрэгт орох, ял зэмлэлд орох** (гэмзэмд холбогдох); *хүн зодсон хэрэгт орж гэнэ);* 2. аливаа газарт очих, хүрэх; *хот орох; зах орох; аймгийн төв орох;* 3. уруу, эсрэг, чиглэн одох; *гол руу орох; эрэг рүү орох; уул руу орох; дайсан руу довтлон оров; гол уруу орох шахав; төв рүү ойртон очив; мод руу ороод жимс түүв;* 4. хэрэглэгдэх, зарцуулагдах; *түлш их орох зуух байна; шавар зуурахад их ус оров; хөдөө явахад бензин их оров;* 5. агаарын тунадас, хур буух; *цас орох; бороо орох; мөндөр орох;* 6. юманд шуналтай, дуртай, сонирхолтой болох; *архинд орох; өнгөнд орох; тоглоомд орох;* 7. бодогдох, сэтгэгдэх; *тэр хүний нэр гэнт дотор ороод ирлээ шүү;* ☆ **нүд орох** (сохор хүн хараатай болох), **зүүдэнд орох** (зүүдэнд сэрэгдэх); **тэргэнд орох** (адгуус малыг тэргэнд хөллөх); **хүч орох** (а. хүчтэй болох, тэнхээтэй болох; б. улам исгэлэн болох): **үнэр орох** (үнэртэй болох, үнэр шингэх); **амт орох** (амттай болох, амт шингэх); **зүрх орох** (зориг орох); **зориг орох** (зориг бадрах); **өнгө орох** (а. сайхан өнгөтэй болох; б. өнгө үзэсгэлэн

сайжрах); **царай орох** (царай сайхантай болох); **хөлд орох** (хүүхдийн анх явж сурах); **хэлд орох** (хүүхэд анх үг хэлж сурах); **үнэд орох** (үнэ нь нэмэгдэх; *алт үнэд орж байна гэнэ);* **үгэнд орох** (дуулгавартай байх, *энэ миниа үгэнд л ордог хүү байгаа юм);* **жил орох** (дорно зүгийн зурхайн ёсны мөчлөгийн жил тохиолдох; *энэ жил гучин долооны бар жил оров);* **ухаан орох** (а. хэрсүүжих: б. ухаан алдсан хүн сэргэх, сэхэх); **амь орох** (а. амилах; б. хөлдүү юм гэсэх, хүйтэн юм бүлээсэх); **голд орох** (а. аминд орох; б. үнэхээр итгэх; *голд ортол итгэмээр үг хэлэв);* **аминд орох** (а. амий нь аврах; б. алах); **онд орох** (онг мэнд эсэн туулах).

ОРОХ II отлох, ороны цаг ирэх; *буур орох; азрага орох; орох тэнгэрийн орой цоорхой, орсон буурын шил цоорхой* з ү й р.

ОРСГОЙ дорсгор, гадагшаа дорсойсон; *орсгой шүд.*

ОРСГОР орсгой, дорсгой.

ОРСОЙЛГОХ орсойхын үйлдүүлэх хэв.

ОРСОЙХ орсгой, дорсгой болох, шүд гадагшаа жишиж ургах.

ОРТОЙ ор, ором бүхий, үнэний хувьтай; *тэр ч ортой юм даг аа.*

ОРТООМ хайнагийн үнээнээс төрсөн үхэр.

ОРТУУЗ у р г а м а л нарийн хатуу навчтай, хөх ягаан цэцэгтэй бутархаг ургамал, хар цагаан хоёр янз бий.

ОРУУЛАХ орохын үйлдүүлэх хэв, ороход хүргүүлэх; *түлхэж оруулах; цохиж оруулах; татаж оруулах;* **санал оруулах** (санал гаргах); **өргөдөл оруулах** (өргөдөл бичиж өргөх); **өөрчлөлт оруулах** (өөрчлөлт хийх); **бүрэлдэхүүнд оруулах** (бүрэлдэхүүнд багтаах); **талдаа оруулах** (талдаа хамааруулах); **хараанд оруулах** (а. хяналтанд авах; б. буудах юмыг бууны хараанд голлуулах); **эрхэнд оруулах** (эрхшээлдээ авах); **гайд оруулах** (гай зовлон болгох); **төөрөгдөлд оруулах** (төөрүүлэх, мунхруулах).

ОРУУЛГА оруулсан юм; *бичгийн оруулга; дээлийн оруулга.*

ОРХИГДОГСОД орхигдсон хүмүүс.

ОРХИГДОХ орхихын үйлдэгдэх хэв, хаягдах, гээгдэх, мартагдах.

ОРХИДОС орхигдсон юм, хаягдас.

ОРХИЛГО 1. хэргээр орхисон юм; 2. цалам, бүгуйль; 3. эхнэр хүний нэгэн зүйл чимэг зүүлт.

ОРХИЛОХ байн байн орхих, юмыг энд тэндгүй хаях, орхих; *явах гэж яраад хамаг хэрэгтэй юмаа орхилочихжээ.*

ОРХИМЖ буддын шашны лам нарын нэгэн зүйл хөлсөвч хувцас; *орхимж нөмрөх.*

ОРХИРОХ 1. барс, буга илжиг зэргийн амьтны дуугарах; 2. орхирох урмын дуугарах; ☆ **орхирох урам** (уриатах урам).

ОРХИУЛ I 1. уяа оосор; *ховооны орхиул;* 2. эхнэр хүний чимэг; 3. орхилго.

ОРХИУЛ II юм орхиж наадах наадам.

ОРХИУЛАХ 1. орхихын үйлдүүлэх хэв; 2. орхигдох.

ОРХИХ 1. үлдээх, хоцроох; *гурван хүнээ буудалд орхисон ажээ; наад түлхүүрээ энд орхичих!* 2. хаях, гээх; *бээлийгээ тэднийд орхичихжээ;* 3. болих, огоорох, хаях; *тамхиа орхих;* 4. гартаа барин сэгсэрч хаях, унагах; *шагаа орхих; шоо орхих;* 5. лам хүний орхимжоо нөмрөх; *орхимж орхих;* 6. туслах үйл үг, нэгмөсөн, бүрмөсөн үйлдэх, хийх; *бичиж орхих; мартаж орхих; хэлж орхив; унтаж орхив.*

ОРХИЦ I бараа нэхэхэд ширхгийг хэрээдэслэн элтэлж хөндлөн орхин нэхэх хэрэгсэл.

ОРХИЦ II монгол бичгийн урагш татсан урт дүрстэй нэг зүйл тэмдэг *орхиц татах.*

ОРХИЦОО орхицох нь.

ОРХИЦОХ 1. гараар бөмбөг булаалдан хаялцан наадах; *бөмбөг орхицох;* 2. ш и л ж с э н үйл явдлыг бие бие рүүгээ түлхэх.

ОРХООДОЙ: хүн орхоодой у р г а м а л хүн эм, алс дорнодод ургах өвсөрхөг ургамал, үндсийг хятад, монгол, төвд эмнэлэгт зүйл бүрийн өвчин эмгэгийг засахад хэрэглэнэ; **далайн орхоодой** а м ь т а н (арьс биржрүүтэй, хэлбэр бөөрөнхий нэг зүйл амьтан, далайд оршино, агнаж арьсаар нь хоол хийнэ).

ОРЦ 1. орох зүйл, орлого, ашиг орлого; 2. малын өвлийн хатуу цагийг туулсан байдал.

ОРЧГОР хорчгор, үрчгэр.

ОРЧИЙХ хорчгор болох.

ОРЧИЛ орчих.

ОРЧИМ 1. орчин, хавь, ойр, тойрон; *тэр орчимд айл олон;* 2. хавь, шахуу; *дөч орчим настай.*

ОРЧИН 1. хавь, ойр хавь, орчим; **ойр орчим** хор.ш.; *орчин үе; хүүхдийн зан авирт орчин тойрон үлэмж нөлөөлнө;* **орчин тойрон** (эргэн тойрны нийгэм-ахуй байдлын нөхцөл, төлөв, хийгээд эдгээр нөхцөлийн нийтлэг зүйлээр холбоо бүхий хүмүүсийн цогц; 2. зайг дүүргэж байгаа бодис, ямар нэгэн зүйлийг тойрон хүрээлж байгаа зүйл; *агаар бол дуу тархан дамжих орчин мөн; давс шингэн орчинд уусна.*

ОРЧИХ эргэх, өнгөрөх, нөгчих; *орчин эргэх.*

ОРЧЛОН мөнх орчихуй дэлхий.

ОРЧЛОНТ: орчлонт ертөнц мөнх хувисан хөдөлж, өөрчлөгдөх материалаг ертөнц.

ОРЧУУЛАГДАХ орчуулахын үйлдэгдэх хэв.

ОРЧУУЛАГДАШГҮЙ орчуулагдаж болшгүй.

ОРЧУУЛАГЧ I ямар нэгэн бичиг хэлийг өөр хэлэнд хөрвүүлдэг хүн; *хятад хэлний орчуулагч; орчуулагч нарын курс.*

ОРЧУУЛАГЧ II эргүүлэгч.

ОРЧУУЛАХ I бичиг хэлийг өөр хэлэнд хөрвүүлэх; *орос хэлнээс монгол хэлэнд орчуулах.*

ОРЧУУЛАХ II 1. орчихын үйлдүүлэх хэв; 2. орчигдох.

ОРЧУУЛШГҮЙ орчуулж болшгүй.

ОРЧУУЛГА I орчуулсан нь; *орос орчуулга; монгол орчуулга; орчуулгын зохиол.*

ОРЧУУЛГА II орчих үйлийн нэр.

ОРЧУУЛУУЛАХ 1. орчуулахын үйлдүүлэх хэв; 2. орчуулагдах.

ОРШ ордог юм, орох юм; *орш их; орш муу.*

ОРШДОС ашигт малтмалын орд; *хүдрийн оршдос.*

ОРШИЛ I ямар нэгэн бичиг зохиолын өмнөх өгүүлэл; *номд оршил бичих.*

ОРШИЛ II шарил булах газар.

ОРШИЛГҮЙ зан авир тогтворгүй.

ОРШИЛТОЙ санаа сэтгэл тогтвортой.

ОРШИНГҮЙ зан авир түвшин тогтвортой.

ОРШИХ 1. суух, нутаглах, амьдрах; *оршин суух газрын нэр; сойр гэдэг шувуу уул модонд оршино; санаа сэтгэл тогтнон орших болов;* 2. байх, бий ахуу; *жинхэнэ шалтгаан нь үүнд оршино;* 3. бие чилж бадайрах; *хөл оршиж орхив;* **өгөх оршихын тийн ялгал** (монголын хэлний гуравдугаар тийн ялгал).

ОРШУУЛАХ I оршихын үйлдүүлэх хэв.

ОРШУУЛАХ II шарил хүүр нутаглуулах; *оршуулах ёслол.*

ОРЬ I залуу, идэр; **орь залуу** хорш.; **орь сайтай** (урамтай, дөжир, хялбар дордохгүй, хатуужилтай).

ОРЬ II бархирах хашгирах дуу; **орь дуу тавих, орь дуу алдах** (энэлж бархирах, орилох).

ОСГООХ осгоход хүргүүлэх, бээрүүлэх.

ОСГОР 1. юманд гарсан өчүүхэн сэв, хортон; 2. осгоруу.

ОСГОРТОХ осгоруутах.

ОСГОРТУУЛАХ осгортохын үйлдүүлэх хэв.

ОСГОРУУ нар салхи зэрэгт осгортон тогтсон сайр.

ОСГОРУУТАХ агаар салхинд нүүр гарын арьс хатаж ширүүн болох; *нүүр осгоруутах.*

ОСГОХ хүйтэнд бээрэн хөлдөж, хөдлөн чадахгүй болох; *осгож үхсэн төлөг; шуурганд осгох.*

ОСГОЧИХ осгож орхих; *би осгочих шахав.*

ОСГОЧУУЛАХ осгочихын үйлдүүлэх хэв.

ОСГУУЛАХ осгохын үйлдүүлэх хэв.

ОСОЛ эндэл, омгтой, хуумгай явдал; *миний осол болов;* **осол цалгар, осол эндэл** хорш.: *авто-машины осол;* **осол гай** (хүний амь үрэгдэх, бэртэх зэрэг аюул, сүйдэл).

ОСОЛГҮЙ 1. лавтайяа; *осолгүй үнэн; осолгүй үзсэн;* 2. гэм аюулгүй; *осолгүй газар; осолгүй техник.*

ОСОЛДОХ 1. осол гарах, омтгойдон гэнэдэх; *тун осолддоггүй хичээнгүй хүн билээ;* 2. үхэх, нас барах; *тулалдаанд осолдов.*

ОСОЛДУУЛАХ осолдохын үйлдүүлэх хэв.

ОСОЛТОЙ 1. гэнэн, болгоомжгүй, лавтай биш; 2. гэм аюул ихтэй; *осолтой өвчин; осолтой зам.*

ОСОХ осгох.

ОСХ осгоруу.

ОТ I отоо.

ОТ II авын хоморгоны үзүүр.

ОТГО х у у ч и р с а н гавьяаны тэмдэг болгож малгайдаа хадаж хэрэглэж байсан тогосын өд.

ОТГОЛОХ эцэслэх, дуусах; *найр отголох; айраг отголох.*

ОТГОН 1. хүүхдийн хамгийн сүүлийнх; *отгон хүү;* 2. эцсийн, төгсгөлийн; *отгон найр; отгон сур;* 3. хөгжмийн утасны хамгийн нарийн; *отгон чавхдас.*

ОТЛОХ мал адгуусны от ороо орох.

ОТОГ I х у у ч и р с а н харьяат албат ардыг хэсэг бүлэг болгон хуваж байсан засаг захиргааны нэгж.

ОТОГ II гөрөөчний уул ойд буудалласан газар; *анчны отог.*

ОТОГЛОХ I 1. х у у ч и р с а н отог болгох, отог байгуулах; 2. отогт багтан орох, захирагдах.

ОТОГЛОХ II гөрөөчний отогт буудаллах.

ОТОЙ одой.

ОТОЛ зэгсний түрүүд бамбарлан ургах унгарил, үүнийг шүүний усанд дүрж уул хийнэ, бас үнгэж олбог дэр мэтэд тавина.

ОТОМДОХ омтгойдох.

ОТОО мал адгуусны цаг үесээр орох ороо; **отоо ороо** х о р ш.; *отооны үе.*

ОТОР малын өвс билчээрийг дагаж хөнгөвчлөн тасарч мал адуулах явдал; *отор хийх; отрын мал.*

ОТОРЛОХ 1. отроор явуулах; *малаа оторлох;* 2. ш и л ж с э н биеэ гамнаж хайрлан ажил явдлаас хойш суух; *биеэ оторлох.*

ОТОРЛУУЛАХ оторлохын үйлдүүлэх хэв.

ОТОРЧИН отор хийх айл хүмүүс.

ОТОРЧЛОХ отроор нүүх, оторлож нүүх, явах.

ОТОХ сэмхэн амдаж хүлээх, тосч хүлээх; *хулгайч барихаар отох; гэртээ ирэхий нь отож байгаад уулзав; муу санаа бие отох* з ү й р.

ОТОЧ их эмч.

ОТОЧЛОХ эмчлэх, анагаах.

ОТОЧЛУУЛАХ оточлохын үйлдүүлэх хэв.

ОТРЯД 1. нэг мэрэгжлийн бүлэг цэрэг; *тэнгэсийн цэргийн отряд; партизан отряд;* 2. нэг үйл ажиллагаа бүхий бүлэг хүмүүс; *пионерийн отряд; хөрс шинжилгээний отряд.*

ОТУУЛАХ отохын үйлдүүлэх хэв.

ОФИЦЕР цэрэг удирдах албаны хүн; *Ардын Цэргийн офицер; Офицерийн ордон.*

ОХИЛОХ юмны охийг тусгай авах; *архи охилох.*

ОХИН 1. эм; *охин хурга; охин унага;* 2. эмэгтэй үр хүүхэд; *таны охин том болжээ.*

ОХИНЦОР охин байдалтай.

ОХОР богино, оодон, урт биш; **охор богино** х о р ш.; *охор дээл; охор бодол; охор санаа;* **охор харавч** (хуягийн нарийн тушам ханцуй); **охор хүч** х у у ч и р с а н (өдрөөр хөлслөх зарц); **охор яс, охор сүүл** (нурууны шувтрага үзүүрийн жижигхэн яснууд).

ОХОРДОХ хэтэрхий охор богино болох, богинодох.

ОХОРДУУЛАХ охордохын үйлдүүлэх хэв, богинодуулах.

ОХЬ I юмны чанар сайтай хэсэг; *архины охь; айргийн охь;* **охь дээж, охь шим** х о р ш.,

ОХЬ II тэргүүн, сод, манлай; *бичгийн зохиолын охь;* **охь манлай** (манлай тэргүүн); **охь од** з у р х а й (дээд удирабадирабад одны орд).

ОЦГОНОХ оцгор юмны оцго оцго хөдлөх байдал.

ОЦГОНУУЛАХ оцгонохын үйлдүүлэх хэв.

ОЦГОР өцгөр, урагш цомбойсон, шомбойсон; *оцгор хад.*

ОЦГОРДОХ хэтэрхий оцгор болох.

ОЦГОРДУУЛАХ оцгордохын үйлдүүлэх хэв.

ОЦГОРХОН баахан оцгор, нилээд оцгор.

ОЦОЙЛГОХ оцойхын үйлдүүлэх хэв.

ОЦОЙХ оцгор болох; *оцойж суух.*

ОЦОЛЗОХ оцгор юмны байн байн хөдлөх.

ОЦОЛЗУУЛАХ оцолзохын үйлдүүлэх хэв.

ОЦОН оцгор болсон нь.

ОЦОС: **оцос хийх** оцгор юмны хоромхон зуур хөдлөх.

ОЧ галаас сацран гарах жижиг цог; **оч харвах, оч үсрэх** (а. галын оч харвах; б. ш и л ж с э н нүдийг юманд цохиулахад оч мэт зүйл сэрэгдэх; *нүднээс оч үсрэх шиг болов*).

ОЧЕРЕДЬ ээлж, ээлж дараа.

ОЧИР 1. бат бэхийн бэлэг тэмдэг; 2. ш а ш и н хоёр захад тав буюу есөн үзүүр гаргаж дүрэм ёсоор үйлдэж ном уншихад хонхтой зэрэгцүүлэн хэрэглэх хэрэгсэл; **элдэв очир** (дөрвөн зах буюу загалмайлан үйлдсэн очир); **очир алмас** (маш хатуу нэг зүйл эрдэнийн чулуу; хатуугийн зэрэг 10, өнгө янзбүр, гоёл чимэглэл, чулуулаг өрөмдөхөд хэрэглэнэ).

ОЧИХ 1. явж хүрэх, тэнд хүрэх; *манайд очих замдаа... эмчид очих; дэлгүүрт очих; очих газар; очих хүмүүсээр хүргүүлэх;* 2. туслах үйл үгийн утгаар; *гүйж очих; нисч очих; гарч очих;* **хүнд очих** (эрд гарах).

ОЧУУЛАХ очихын үйлдүүлэх хэв.

ОЧУУШТАЙ очих шаардлага хэрэгцээ бүхий.

ОЮУ хөх буюу ногоон өнгийн эрдэнийн чулуу гоёлд хэрэглэнэ.

ОЮУЛАХ оёхын үйлдүүлэх хэв.

ОЮУН ухаан, билэг; **оюун билэг, оюун ухаан** х о р ш.; **оюуны хөдөлмөр** (биеэр биш, ухаан бодлоор хийх хөдөлмөр; *оюуны хөдөлмөрийн хүмүүс*).

ОЮУТ 1. оюу бүхий; 2. оюун ухаан бүхий.

ОЮУТАН 1. дээд сургуулийн сурагч; *Улсын их сургуулийн оюутан; оюутны зөвлөл; Олон улсын Оюутны холбоо;* 2. *сэхээтэн;* **оюутан сэхээтэн** х о р ш.

Ө

Ө ө авиа, ө эгшиг.

ӨВ 1. эзэмшиж байсан хүний нас барахад өөр хүнд шилжин очих хөрөнгө: **өв хөрөнгө, өв хувь** х о р ш.; *эцгээс үлдсэн өв хөрөнгө; өв хувиа авах; өв идэх; өв булаалдах;* 2. өнгөрсөн үе, урьдын зүтгэлтнээс уламжлан авсан соёл, аж амьдрал зэргийн үзэгдэл; **өв соёл** х о р ш.; *манай ард түмний соёлын өв.*

ӨВГӨД 1. олон өвгөн; 2. эцгийн дээд үеийн төрлийн хүмүүс; *өвгөд дээдэс; өвгөдийн үг* (эртээс уламжилсан үг); *өвгөд ирвэл үг нэмнэ хүүхэд ирвэл хүч нэмнэ* з ү й р.

ӨВГӨЛЖИНӨ а м ь т а н толгой хар, оройд гэзгийн адил уртхан хар чандар бүхий нэг зүйл бялзуухай.

ӨВГӨН 1. насжисан, хөгширсөн эр хүн; *бууral өвгөн; цагаан өвгөн; эрт урьд цагт нэг эмгэн өвгөн хоёр байж гэнэ* (үлгэрээс); 2. хөгшин, нас өндөр; *нас өвгөн болох;* 3. я р и а зарим үерхэн нөхөрлөх хүмүүс бие биесийгээ ингэж дуудна; *өвгөн өө, чи над заавал хэлнэ шүү;* ☆ **долоон өвгөн** з у р х а й (долоон бурхан).

ӨВДӨГ I 1. дунд чөмөг шаант хоёрын уулзар үе; өвдөгний үе; *ус өвдгөөр татаж байна; өвдөг дээрээ сөхрөх; өвдөг зэрэгцэн суух;* **өвдөг шороодох** (барилдаж унах); **өвдөг мушгих** (бөхийн мэх); **өвдөгний нүд** (өвдөгний тойгийн доод этгээдэд байх эмзэг газар); **өвдөг хумбих** (нэг хөл бохирон суух); 2. өмдний өвдөг орчмын газар; *өмдний өвдөг;* 3. я р и а адгуус малын богтос шилбэ хоёрын уулзар үе, урд хөлийн сөхрөн нугарах үе; *малын өвдөг;* 4. тэмээний өвдөгний дээдэх сахлаг ноос; *тэмээний өвдөг зогдор авч байв;* 5. ш и л ж с э н уулын бэлийн түгдгэр газар; *уулын өвдөг.*

ӨВДӨГ II нүдний сормосны сурвалжийн тослогийн булчирхай идээлэн үрэвсэх өвчин; *нүдэнд өвдөг гарах.*

ӨВДӨГДӨХ өвдөгнөөс нь барих.

өвдөглөгдөх өвдөглөхийн үйлдэгдэх хэв.

өвдөглөх 1. юмыг өвдгөөр дарах, нухах; *өвдөглөж байгаад дарж гэнэ;* 2. өвдөгт тулгаж татах; *өвдөглөн хугалах.*

өвдөглүүлэх 1. өвдөглөхийн үйлдүүлэх хэв; 2. өвдөглөгдөх.

өвдөгцөө өвдөг хүрэхүйц, өвдөг хүрэм; *өвдөгцөө ус, өвдөгцөө цас.*

өвдөгч I 1. өмдний гадуур өвдөг орчин газрыг халхлан өмсөх хувцас; 2. ботгыг нялх цагт нь өвдөгт нь уяж уяанд торгох оосор.

өвдөгч II бяцхан амтай богинохон хүзүүтэй, шингэн зүйл хийх гонзгор ваар сав; *архины өвдөгч; эрээн өвдөгчтэй архи.*

өвдөл: өвдөл цөвдөл идэш идээний жижиг хог; **өвдөл цөвдөл** х о р ш..

өвдөлт өвдөх үйлийн нэр, өвдөх явц; *өвдөлтийн байдал ямар байна?*

өвдөм өвдмөөр. ? ?

өвдөөх өвдөхөд хүргүүлэх.

өвдөх 1. эвэрлэх, эвэршээх, нэрвэгдэхийг мэдрэх; *толгой өвдөж байна; өвдтөл цохих; дотор өвдөх;* 2. өвчин тусах; *өвдсөн учир хичээлдээ эс ирэв.*

өвдүүлэх өвдөхийн үйлдүүлэх хэв.

өвлөх өвийг эзлэх, өв идэх; *эцгийн хураасныг хүү нь өвлөв.*

өвлүүлэх өвлөхийн үйлдүүлэх хэв.

өвөг I эцгийн дээд үетэн; **өвөг дээдэс** (өөрийн эцэг ба түүнээс дээших үе); **өвөг эцэг** (эцгийн эцэг); **элэнц өвөг** (өвөг эцгийн эцэг); **хуланц өвөг** (элэнц эцгийн эцэг).

өвөг II зарим шувуу, хэвлээр явагчдын толгой дээр ургасан зүйл; *шувууны өвөг.*

өвөгжөөл өвөгжөөр.

өвөгжөөр хөгшин, хөгширсөн дүртэй, овор ихтэй; *өвөгжөөр хүн.*

өвөгрөх өвгөн болох, хөгшрөх.

өвөгрүүлэх өвөгрөхийн үйлдүүлэх хэв.

өвөгт өвөг бүхий; *өвөгт шувуу.*

өвөгчлөх өтгөс хөгшдийг хүндлэх.

өвөл жилийн дөрвөн улирлын хамгийн хүйтэн улирал, намрын дараа ирнэ; *хатуу өвөл; хүйтэн өвөл; өвлийн дунд сар; өнтэй өвөл; өвлийн хувцас; өвлийн хүйтэн;* **өвлийн туйл** (сарын зурхайн ёсны жилийн хорин дөрвөн улирлын нэг, өдрийн богинын туйл, ес эхлэх цаг); **өвлийн уур** (сарны зурхайн ёсны жилийн хорин дөрвөн улирлын нэг, намар өнгөрөн өвөл болж эхлэх үе; өвлийн уур орох); *өвлөөр хөдөө явах гэдэг амаргүй хэрэг; өвлийн хүйтэн хавартаа, өвгөдийн гэрээс хүүхдэд з үйр.*

өвөлжин өвлийн турш; *өвөлжин аянд явав.*

өвөлжих өвлийг өнгөрөөх, туулах; *хотод өвөлжих; өвөлжөөндөө өвөлжиж байв.*

өвөлжөө өвлийг өнгөрүүлэх хашаа хороо бүхий нутаг бууц; *өвөлжөөгөө засах; хавар болж айлууд өвөлжөөнөөс гарч байна.*

өвөлжөөлөх хүйтэн улирал болоход өвөлжөөнд буудаллах, буух.

өвөлжөөлүүлэх өвөлжөөлөхийн үйлдүүлэх хэв.

өвөлжүүлэх өвөлжихийн үйлдүүлэх хэв, өвөлжихөд хүргүүлэх, өвлийг өнгөрүүлэх.

өвөөлж бөвөөлж шувуу.

өвөр I арын эсрэг утга; 1. юмны өмнөх, энгэр, урд этгээд; *уулын өвөр; байшингийн өвөр; биеийн өвөр тал; манай мал хайрханы өвөрт билчиж байна;* **өвөр зурхай** (сур харвахад сур өрөх газрын нүүр этгээдэд хоёр нум хэмжиж зурсан зураас; харвасан сум өвөр зурхайгаас дотогш тусвал дутсанд тооцно); **өвөр Монгол** (Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нутагт орших Монголчууд); 2. суугаа хүний өвдөг дээрх зай; *өвөр дээр суух.*

өвөр II 1. бүсэлсэн дээлийн энгэрийн дотор байх хөндий зай; *өвөр дотроос нь алчуур тай юм гарав;* 2. нөмөрсөн хувцас хунарын дотоод нь; *нялх хүүхдээ өвөртөө авч унтдаг байв;* 3. карман, хувцасны юм агуулахаар хийсэн бяцхан уут; *цамцны өвөр;* **өвөр карман** х о р ш.; ☆ **өврийн дэвтэр** (өвөртөлж явахад зориулсан жижиг дэвтэр).

өвөрлөгч өвөр Монгол, өмнөд Монгол; *өвөрлөгч хүн; өвөрлөгчид.*

өвөрлөх I 1. өвөртлөх; 2. ш и л ж с э н ашөө хорогол хадгалах; *ашөө өвөрлөх.*

ӨВӨРЛӨХ II уулын өвөр газраар явах; *хонь уул өвөрлөж билчив.*

ӨВӨРЛҮҮЛЭХ өвөрлөхийн үйлдүүлэх хэв.

ӨВӨРМӨЦ бусдаас өөр, онцгой, энгийн ердийнхтэй адилгүй, тусгай; *өвөрмөц байдал; өвөрмөц заншил; өвөрмөц чанар; өвөрмөц урлаг; өвөрмөц үзэх.*

ӨВӨРТЛӨХ 1. юмыг өвөрт хийх, агуулах; *хавтгатай тамхиа бүснээсээ зүүсэнгүй өвөртөлж орхив;* 2. нөмөрсөн хувцас хунарын дотор агуулах; *өвөртөлж унтах; хүүхэд өвөртлөх.*

ӨВӨРТЛҮҮЛЭХ өвөртлөхийн үйлдүүлэх хэв.

ӨВӨРЧ I цуцамтгай.

ӨВӨРЧ II хэгэрхий тал тохой татагч.

ӨВӨРЧЛӨХ 1. өмчлөх; 2. ш и л ж с э н бусдыг тал тохой татах, дотночлон үзэх; 3. засдаглах, тоёчлох, үнэн биш үйлдэх; 4. өөрчлөх.

ӨВРӨХ I хүчин гүйцэхгүй мохох; *өвөрч доройтож цуцах.*

ӨВРӨХ II хөвт дарагдах, хүүрших; *өвөрч муудсан эд бараа эдлэгээ муутай.*

ӨВРӨХ III эврэх; *мод өврөх.*

ӨВС (ӨН) 1. мод, бутаас бусад аливаа нарийн ногоон иш бүхий ургамал; **өвс бордоо, өвс ногоо,** х о р ш.; *зэрлэг өвс; эмийн өвс;* **өвс шиг хийсэх** (маш хөнгөн юмны тухайд); **өвсөн гэр** (гэрийн муушаал; *өвсөн гэр нь хийсээд явчихжээ, үнхэлцэг тогоо нь хагараад явчихжээ* (үлгэр); 2. мал тэжээхийн тул хадаж хатаасан ногоо; *өвсөн овоохой;* **өвсөнд гарах** (өвс хадахаар явах, хадланд гарах); **өвснөөс буух** (өвсний ажил дуусах); **өвсний хадуур** (өвс хадах багаж); **өвс нуруулдах** (хадсан өвсийг ихээр овоолох); **өвсний хашаа, өвсний хороо** (өвс агуулах сав); **өвс бухалдах** (хадсан өвсийг бага багаар овоолох); **өвс дүйзлэх** (а. хураасан өвсийг бага багаар боох; б. хураасан өвсийг бага багаар овоолох).

ӨВСВЭЭН өөрөө, аяндаа; *өвсвээн мэдэх хэрэгтэй.*

ӨВСЛӨХ малд өвс тавьж өх, идүүлэх; *ухрээ өвслөх цаг болжээ.*

ӨВСЛҮҮЛЭХ өвслөхийн үйлдүүлэх хэв.

ӨВСӨРХӨГ 1. өвс ихтэй; 2. өвс мэт; *өвсөрхөг ургамал.*

ӨВСӨРХҮҮ 1. өвсөрхөг; 2. өвстэй төстэй.

ӨВСТӨХ тариаланд зэрлэг өвс хольцолдон ургах.

ӨВСЧИН өвсний ажил хийж яваа хүмүүс.

ӨВТГӨӨХ өвдөхөд хүрүүлэх, зовоох, шаналаах.

ӨВТГӨХ өвдөхийн үйлдүүлэх хэв, өвдөхөд хүрүүлэх.

ӨВТГҮҮЛЭХ өвтгөхийн үйлдүүлэх хэв, өвтгөхөд хүрүүлэх.

ӨВХГӨР 1. урагш бөгтийн тонгойж суусан буюу бөгтөр мэхгэр; *морин дээрээ нэг өвхгөр амьтан суужээ;* 2. хөвхгөр

ӨВХИЙЛГӨХ 1. өвхийхийн үйлдүүлэх хэв, өвхгөр болгох; 2. хөвхийлгөх.

ӨВХИЙХ 1. өвхгөр болох; *морин дээрээ өвхийн үзэмж муутай сууж явлаа;* 2. хөвхийх.

ӨВХӨГ: өвхөг өвхөг хийх өвхгөр юмны үргэлжлэн хөдлөх.

ӨВХӨГНӨХ 1. өвхгөр юмны өвхөг өвхөг хөдлөх; 2. хөвхөгнөх.

ӨВХӨГНҮҮЛЭХ өвхөгнөхийн үйлдүүлэх хэв.

ӨВХӨЛЗӨХ 1. өвхгөр юмны өвхөс өвхөс хөдлөх; 2. хөвхөлзөх.

ӨВХӨС: өвхөс өвхөс хийх өвхгөр юмны байн байн хөдлөх.

ӨВЦӨЛДӨХ өвцөхийн үйлдэлдэх хэв.

ӨВЦӨЛДҮҮЛЭХ өвцөлдөхийн үйлдүүлэх хэв.

ӨВЦӨХ цус хольцох.

ӨВЧ бүрэн, төгс, бүхэл; *өвч хувцас; өвч бүрэн хэрэглэлтэй гэр; өвч хуяг.*

ӨВЧИН 1. эрүүл биш байдал, бие махбодийн зөв зохист үйл ажиллагааны хэвийн биш байдал, самуурал, хямрал; **өвчин зовлон, өвчин эмгэг, өвчин тахал** х о р ш.; *хүнд өвчин; халдварт өвчин; нүдний өвчин; өвчин тусах;* 2. эмзэг, өвдөх нь мэдрэгдэх; *өвчин орох; өвчин нь ихдэх;* **өвчин тарих** (өвчин нь бусдад тархах); **өвчин тусах** (өвчин хүрэх, өвчин олох, өвдөх): **өвчин ээрэх, өвчин ороох, өвчин эргүүлэх** (өвчин салахгүй болох); **өвчинд шаналах** (өвчинд нэрвэгдэж маш зовох); **өвчин**

олох (өвчин хүртэх); **өвчин хүртэх** (өвчтэй болох); **өвчин хүндрэх** (өвчин чангарах); **өвчин хүнддэх** (өвчин хүндрэх); **өвчинд баригдах** (өвчин салахгүй болох); **өвчинд нэрвэгдэх** (өвчинд доройтох); **өвчин ялаарших** (өвчин хөнгөрөх); **ужиг өвчин** (авсаар эдгэрэхгүй удсан архаг өвчин); **өвчин үгдрэх** (өвчин дахин хүндрэх, хүндрэлд орох); **арьсны өвчин** (арьсанд гарах өвчин); **халдварт өвчин** (аливаа хүн амьтан, юмнаас дамжин халдаж эхлэх өвчин): **өвчин дарах** (а. өвчин намдах; б. өвчин ээрэх); **өвчний хуудас** (өвдсөний учир олгосон магадлах хуудас).

ӨВЧИНГҮЙ эрүүл чийрэг; *өргүй бол баян, өвчингүй бол жаргал* з ү й р; *үүлгүй өдөр сайхан, өвчингүй бие сайхан* з ү й р.

ӨВЧИХ арьс хальс зэргийг шаалан, хуулан салгах; *нядалсан хонины арьсыг өвчих.*

ӨВЧЛӨХ өвдөх, өвчин олох, өвчин тусах.

ӨВЧЛҮҮЛЭХ өвчлөхийн үйлдүүлэх хэв.

ӨВЧТӨН өвчин бүхий хүмүүс; *эмнэлэгт хэвтэж байгаа өвчтөн; өвчтөнийг сувилах; өвчтөнийг хүлээн авах газар.*

ӨВЧТЭЙ 1. эмзэг, өвдөх нь мэдрэгдэх нь; *тэнд дарахад өвчтэй байна;* 2. өвчин туссан, өвдсөн нь; 3. ш и л ж с э н нэрэлхүү, хөөргөн, сагсуу, онгироо, балмад байдалтай; *өвчтэй амьтан.*

ӨВЧҮҮ (Н) амьтны цээжний өвөр этгээдэд хавирганы бөгсний мөгөөрсөөр залгалдсан уртавтар хавтгай яс; *өвчүү хошного; өвчүү цорой; өвчүүний ойс* (уйс); **өвчүүний халбага** (аймхай мөгөөрс); **өвчүүний хуруу** (өвчүүний хажуугийн хавиргад залгасан бяцхан яс); **өвчүү түших** (нядалсан малын гэдэс дотор гаргахад цээж этгээдийг тэгш түвшин байлгахаар түших); **өвчүүнд түшүүлэх** (үнэхээр санаа тавьж хичээнгүйлэх).

ӨВЧҮҮЛЭХ өвчихийн үйлдүүлэх хэв.

ӨГВИЙХ өөвийх.

ӨГВӨГӨР сөвгөр.

ӨГИЙ 1. эгч; **өгий эгч** х о р ш.; 2. эмэгтэй хүнийг дуудах хүндэтгэл.

ӨГЗӨГ бөгсний тус тонтгор газар; *тонтгор өгзөг; өгзгийн мэдрэлийн судал.*

ӨГЛӨГ өгцөө, өр; **өглөг авлага** х о р ш.; *тэр над, өглөгтэй хүн;* 2. туслахыг бодож өгөх юм; *өглөг өгөх;* **өглөгийн эзэн** (өглөг өгөгч).

ӨГЛӨГЛӨХ өглөг 2-ыг өгөх

ӨГЛӨГЧ өглөг өгөх дуртай; *өглөгч хүн; өглөгч хүн өөртөө хоосон.*

ӨГЛӨӨ үүр цайхаас эхлэн бага үд хүртлэх үе; *өглөө эрт; өглөө бүр; маргааш өглөө; өглөөний цай; өглөөний нар шарж байна; өглөөний мэнд хүргэе; өглөөний дулааныг дулаанд бүү бод, өсөхийн жаргалыг жаргалд бүү бод* х у у ч.

ӨГЛӨӨГҮҮР өглөө, өглөө эрт; *бид онгоцоор өглөөгүүр нисэв.*

ӨГНӨХ өн болох; *өвөлд нь өгнөж, зунд нь сөгнөж ...* (ерөөлийн үг); **өгнөх сөгнөх** х о р ш..

ӨГӨГДӨХ өгөхийн үйлдэгдэх хэв.

ӨГӨЛЦӨХ 1. өгөхийн үйлдэлцэх хэв; 2. я р и а н ы ямар нэг үйл явдлыг хамт үйлдэх.

ӨГӨӨ: өгөө аваа өглөг авлаг, өгцөө авцаа; **өгөө аваатай; өгөөтэй аваатай** (а. бие биесдээ харилцан хариутай, найзтай; б. ш и л ж с э н дийлэх, дийлэгдэх (хүч тэнцүү).

ӨГӨӨМӨР 1. өглөгч ,харам сэтгэлгүй; *өгөөмөр хүн;* 2. элбэг дэлбэг, баян тарган; *өгөөмөр баян хангай; өгөөмөр жил; өгөөмөр баян нэгдэл.*

ӨГӨӨМӨРЧ өгөөмөр, өглөгч.

ӨГӨР 1. өнгө зүсний зэвхий саарал; *өгөр өнгөтэй даавуу;* 2. гутранги байдалтай; *өгөр газар; өгөр даах.*

ӨГӨРШИХ 1. өгөр шинж орох; *нар салхинд өгөршсөн даавуу;* 2. хүүрших, хэврэгших.

ӨГӨРШҮҮЛЭХ өгөршихийн үйлдүүлэх хэв.

ӨГӨХ авах гэдгийн эсрэг утга; гардуулах, олгох, мэдэлд шилжүүлэх, өглөг болгох; *мөнгө өгөх; ном өгөх; шагнал өгөх; гардуулж өгөх; бэлэг өгөх; баярын бичиг өгөх; хоол өгөх; унд өгөх; цай өгөх; эм өгөх;* ☆ **заавар өгөх** (зааварлах); **амсаж өгөх** (амсах); **худалдаж өгөх** (худалдах); **даалгавар өгөх** (даалгах); **зөвшөөрөл өгөх** (зөвшөөрөх); **тушаал өгөх** (тушаах); **цохилт өгөх** (цохих); **хариулт өгөх** (хариулах); **зааж өгөх** (заах); **нэр өгөх** (нэртэй болгох); **хоч өгөх** (хочлох); **дохио өгөх** (дохио мэдрэгдэх); **хэл өгөх** (хэл мэдээ сонсгох): **ам өчиг өгөх** (хэлсэн үгэндээ хүрнэ гэж батлах); **өчиг өгөх** (мэдүүлэг өгөх); **мэдүүллэг өгөх** (ялтан хэрэгтэн хүмүүсийн мэдүүлэх); **бууж өгөх** (дагаж орох); **са-**

нал өгөх (санаагаа гаргах); **хүч өгөх** (хүчин туслалцах); **үнэ өгөх** (үнэ нэмэх; *би тэр моринд нилээд их үнэ өгсөн юм);* **сэтгэлээ өгөх** (үнэн сэтгэлээсээ дурлах, хайрлах); **эрх өгөх** (эрх олгох); **үг өгөх** (тангараглах); **жишээ өгөх** (а. үлгэр жишээ үзүүлэх; *багачуудад ахуй байдлаараа жишээ өгөх хэрэгтэй* б. жишээ гаргах; жишээлэх; *сурагчдад их тодорхой жишээ өгч байх хэрэгтэй);* **өгч явуулах** (авахуулан явуулах); **барьж өгөх** (аливаа салсан, зугтсан, нуугдсан хүн юмыг барьж хүргэх, илрүүлэх; *морь барьж өгөв; хулгайч нарыг барьж өгөв);* **үзэж өгөх, харж өгөх** (а. хийсэн юмы нь үзэж танилцаж өгөх; *бичсэн зохиолы нь үзэж өгөх;* б. хэлсэн хүссэний нь ямар нэгэн юмнаас харж өгөх; *дансад үзэж өгөв);* **хэмжээ өгөх** (а. биеэ хэмжүүлэх; *би хувцасны газар очиж хэмжээ өгөөд ирлээ;* б. аливаа юмны хэмжээг мэдэгдэх); **өгөх оршихын тийн ялгал** (монгол хэлний гуравдугаар тийн ялгал); *өгөх хүн гэдийх, авах хүн бөхийх* з ү й р.

ӨГРӨХ 1. өгөр болох; 2. хуучирч хэврэгших, хувцайрах; *гэрийн бүрээс өгөрч орхив.*

ӨГРҮҮЛЭХ өгрөхийн үйлдүүлэх хэв.

ӨГСӨӨХ өгсөхөд хүргүүлэх.

ӨГСӨХ уруудахын эсрэг утга; өөдөө хөдлөх, явах, өндөр, өөд явах; *уулын ам өөд өгсөх; гол өөд өгсөх; өгсөж явах;* **өгсөх уруудах** х о р ш..

ӨГСҮҮЛЭХ өгсөхийн үйлдүүлэх хэв.

ӨГСҮҮР их өгсдөг; *өгсүүр газар.*

ӨГТӨХ 1. өгөгдөх; 2. ш и л ж с э н дийлэгдэх, давагдах; **мөчөөгөө өгтөхгүй** (дийлэгдэхгүй, давагдахгүй).

ӨГҮҮЛБЭР х э л з ү й тусгайлан утга төгссөн санаа бүхий, утгын талаар харилцан нягт холбоотой бүлэг үгс; *энгийн өгүүлбэр; нийлмэл өгүүлбэр; өгүүлбэрийн гишүүн; гишүүн өгүүлбэр;* **өгүүлбэрийн зүй** (өгүүлбэрт үг холбох, өгүүлбэрийн тухай судлах хэл зүйн хэсэг).

ӨГҮҮЛЛЭГ эрдэм шинжилгээ, уран сайхны багашиг хэмжээний зохиол; *эрдэм шинжилгээний өгүүллэг; үргэлжилсэн үгийн зохиолд өгүүллэг орно.*

ӨГҮҮЛШГҮЙ I хэлж баршгүй; *өгүүлшгүй сайхан өгүүлшгүй муухай.*

ӨГҮҮЛШГҮЙ II өгч болшгүй ,илгээж болшгүй.

ӨГҮҮЛЭГДЭХҮҮН өгүүлбэрийн доторхи жинхэнэ өгүүлэгдэж байгаа хүн, юм буюу үзэгдлийн нэр; *гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн.*

ӨГҮҮЛЭЛ 1. хэлэх үг, өгүүлэх үг: **үг өгүүлэл** х о р ш.; **үг өгүүлэл гаргах** (дургүйцэж үг яриа ярих); 2. эмхэтгэл, сэтгүүл, сонин зэрэгт гаргах хялбарчилсан багашиг хэмжээний зохиол; *сонинд өгүүлэл бичих;* ☆ **өмнөх өгүүлэл** (ямар нэгэн зохиолын удиртгал, оршил, өмнө нь байх өгүүлэл).

ӨГҮҮЛЭХ I хэлэх, ярих; *өгүүлэх нь ... чингэж өгүүлсэнд ...*

ӨГҮҮЛЭХ II **өгөхийн** үйлдүүлэх хэв, өгөхөд хүргүүлэх.

ӨГҮҮЛЭХҮҮН өгүүлэгдэхүүний чухам хэрхсэн яасан, ямар, юу болохыг хэлсэн үг.

ӨГЦӨӨ бусдад өгөх өр өглөг; *өгцөөтэй хүн.*

ӨГЧИЛГӨХ бусдад өгөх юмыг бусдаар илгээх, хүнээр явуулах, өгч илгээх; *дараа хүн явахад гутлы чинь өгчилгөө.*

ӨГЬЕӨ шувуу, мэрэгчний тэжээл; *оготны өгьеө.*

ӨД (ӨН) шувууны биед байх, хоёр талааараа үсэрхэг сэртэнтэй хөндий эвэр гуурс; *тахианы өд; сумны өд;* **өдөн малгай** (сөд мэт зөөлөн үсээр хийсэн нэг зүйл малгай); **өдтэй бичиг** х у у ч и р с а н (маш яаралтай гэж шувууны өд нааж илгээх бичиг; *өдтэй бичиг нь өртөөгөөр дамжина хөө* ... (ардын дуу); **өдөн гүвүүр** (шувууны өд нийлүүлэн баглаж хийсэн юм гүвэх хэрэглэл); **өдөн үүл** (шувууны өд мэт харагдах нэг хэлбэрийн үүл); **өднөөс хөнгөн, сумнаас хурдан** (мал имнэх, хөнгөлөхөд хэлэх үг).

ӨДИЙ I цаг үе болоогүй, цаг үе нь болтол удах, дэндүү эрт; *бид явах өдий; тулгаж гүйцэх өдий байна, дөнгөж хагаст нь хүрчээ.*

ӨДИЙ II 1. энэ зэргийн, ийм хэмжээний; *өдий их бараа буулгаж байхад ... өдий өндөр болл өдий төдий хүн амьтан;* **өдий төдий** х о р ш.; 2. энэ үе, энэ цаг, энэ хир, эдүгээ; *говьд өдийд дулаахан байгаа; маргааш өдийд бид хотод байна.*

ӨДИЙХӨН I баахан өдий.

ӨДИЙХӨН II дэндүү жаахан, дэндүү бага, ийм жаахан, ийм бага; *өдийхөн чинээ; өдийхөн юмыг өгсөнд орвол байсан нь дээр.*

ӨДИЙЧНЭЭ энэ зэргийн, ийм хэмжээний; *өдийчнээ их; өдийчнээ урт.*

ӨДЛӨХ 1. өд нь ургах; 2. шувууны өд ноолуурыг зулгаах; 3. суманд өд наах; *сум өдлөх.*

ӨДЛҮҮЛЭХ өдлөхийн үйлдүүлэх хэв.

ӨДӨӨГЧ үүсгэгч, сэдэгч, үүсгэдэг; *хатган өдөөгч; халдан өдөөгч; дайн өдөөгч* •

ӨДӨӨЛ өдөөх үйлийн нэр, өдөөсөн, сэдсэн нь. •

ӨДӨӨЛГӨХ өдөөхийн үйлдүүлэх хэв, өдөхөд хүргүүлэх.

ӨДӨӨЛӨГ өдсөн, сэдсэн, **өдөөл**, *түүний өдөөлгөөр ийм болов.*

ӨДӨӨХ өдөхөд хүргүүлэх, өдөхийн үйлдүүлэх хэв, сэдэх; *хэргүүл өдөөх; өдөөн хатгах; империалистууд дайн өдөөхийг хүсч байна.* •

ӨДӨР 1. нар гарах цагаас нар шингэх хүртлэх уе; *гэгээн цагаан өдөр; өдөр уртсах; өдөр гурвалжин, шөнө дөрвөлжин;* о н ь с г о ; **өдөртөө хүрэх** (нэг өдрийн дотор хүрэх); **өдөр шөнөгүй** (яаран, яаравчлан; *өдөр шөнөгүй явсаар хүрч ирэв);* **өдөр өнгөрөхгүй** (уйтгартай, цаг нөгцөхгүи); **өдөр бүр** (өдөр бүхэн; *өдөр бүрийн хэрэглэхүүн; өдөр бүр хуртай; өдөр бүр ажилтай);* **өдөр туж** (өдөр дуустал, өдөр турш); **өдөр турш** (өдөр туж); **өдөр дуусан** (өдөр туж); **өдөр тутам** (өдөр бүр); **өдөр дүл** (өдөр дунд); **бүтэн сайн өдөр** (Ням гариг); **хагас сайн өдөр** (Бямба гариг); **баярын өдөр** (чухал үйл явдлыг тэмдэглэн, хууль ёсоор амрах өдөр); **өдрөөс өдөрт** (улам бүр, улам бүрий, *миний бие өдрөөс өдөрт сайжирсаар байв);* **төрсөн өдөр** (хүний мэндэлсэн өдөр; *төрсөн өдрийн баяр болов);* **өдрийн сонин** (а. өдөр тохиолдсон үйл явдал; б. өдөр тутам хэвлэн нийтлэх сонин); **өдрөө хүлээх** (өвдсөн хүний үхэх цаг ойртох); **аймралтын өдөр** (хуулиар тогтоосон амрах өдөр); 2. хоног; *гурван өдрийн чөлөө авчээ; цөөн өдөр үлдэв;* 3. нэгэн хоногийн доторхи ямар нэг үйл ажлыг гүйцэтгэх хугацаат цаг; **ажлын өдөр** (өдөрт ажиллах, хуулиар тогтоосон хугацаа); **хөдөлмөр-өдөр** (нэгдлийн гишүүдийн хөдөлмөрийг бүртгэх нэгж; *хөдөлмөр-өдөр хийх);* **өдрийн од шиг** (хаяа нэг, маш ховор); *өдрийн сайныг өнжин хүлээж, сарын сайныг саатан хүлээж* (ерөөл).

ӨДӨРЖИН нэг өдөр дуусан, өдрийн турш; *өдөржин ном уншиж суув;* **өдөржин шөнөжин** (нэг өдрийн шөнийн турш).

ӨДӨРЛӨХ бичигт өдөр сарыг тэмдэглэн бичих.

ӨДӨРЛҮҮЛЭХ өдөрлөхийн үйлдүүлэх хэв

ӨДӨХ анх эхэлж үүсгэх, гаргах, хатгах, халдах, сэдэх; *уг өдөх; хэргүүл өдөх;* **өдөх сэдэх, өдөх хатгах** х о р ш . .

ӨДҮҮЛБЭР үүсгэл, анх өдсөн, сэдэв, шалтгаан.

ӨДҮҮЛБЭРЛЭХ өдүүлбэр гаргах, анх өдөх, сэдэх.

ӨДҮҮЛЭХ өдөхийн үйлдүүлэх хэв, өдөхөд хүргүүлэх; *хэрэг өдүүлэх.*

ӨЕГ 1. нүнжигтэй, шимтэй, тэжээлтэй; *өег хоол;* 2. цатгалан, гэдэс цатгалан; *гэдэс өег байна;* **өег цатгалан** х о р ш . ; 3. шунахай биш, ховдоггүй; *өёг болсон хүн.*

ӨЕГДӨХ 1. хэтэрхий өег болох; 2. ихэд даарч зүдэрч маш доройтох.

ӨЕГДҮҮЛЭХ өегдөхийн үйлдүүлэх хэв.

ӨЕГШИХ өегийн шинжтэй болох.

ӨЕӨ гэдэргэн хэлбүү; *өеө газар.*

ӨЕӨДӨХ I хэтэрхий өеө болох.

ӨЕӨДӨХ II 1. хэелэн ойчих, хазгай газар хэелэн ойчоод авд босч чадахгүй байх, *би орон дээрээсээ өөдөөж унав;* 2. амьтны туранхлан ядрах зэргээр хөдөлж ядах, байн баин унах болох; *хурга өөдөөд уначихав.*

ӨЕӨДҮҮ нилээд өеө.

ӨЕӨСӨХ өеөдөх.

ӨЕХ өехий; *малын өех.*

ӨЕХИЙ 1. адгуус амьтны өвчүүнээс доошхи газар; *өехий цагаан;* 2. зарим амьтны арьс шир ийг өвчихөд умдагнаас эрүү хүртэл тусгаи зурваслан хуулсан арьс.

ӨЕХИЙЛЭХ өехийн арьсыг зурвас авах.

ӨЕХИЙЛҮҮЛЭХ өехийлэхийн үйлдүүлэх хэв.

ӨЕХӨН I уужим, чөлөөтэй, өлхөн.

ӨЕХӨН II хэвгий, баахан өеө; өехөн газар.

ӨЖ нөр, өжүүн, зөрүүд; *өж нөр.*

ӨЖИЛТ өжих үйлийн нэр.

ӨЖИМТГИЙ хэтэрхий өжүүн.

ӨЖИМХИЙ өжимтгий.

ӨЖИНГӨ өжүүн зантай.

ӨЖИНХИЙ өжимтгий, өжимхий.

ӨЖИХ I өжүүн, зөрүүд зан гаргах; *чи битгий өжөөд бай!*

ӨЖИХ II 1. муудах, гутах; 2. самуун, завхай.

ӨЖӨӨХ өжихийн үйлдүүлэх хэв, өжихөд хүргүүлэх.

ӨЖҮҮ 1. зөрүүд, хөшүүн; *өжүүгий нь хөдөлгөх;* 2. хэрцгий, гажуу.

ӨЖҮҮН зөрүүд, өжих зантай; гажуу *өжүүн хүн.*

ӨЖҮҮРХҮҮ өжүүрхэг.

ӨЖҮҮРХҮҮЛЭХ өжүүрхэхийн үйлдүүлэх хэв, өжүүгий нь хөдөлгөх.

ӨЖҮҮРХЭГ баахан өжүүн зантай, өжүүрхүү.

ӨЖҮҮРХЭХ өжүүн зан гаргах; *өжүүрхээд хөдөлж өгсөнгүй.*

ӨЛ I 1. шим, тэжээл: **өл шимгүй** (шим тэжээлгүй); **өлтэй хоол** (шим тэжээл ихтэй хоол); 2. тэжээл, хоол; *өл хоолгүй явах;* **өл муутай** (тэжээл муутай); **өл залгах** (хоол тэжээлтэй залгах); **өл даахдаа сайн** (хоол идэхгүй удаан байж чадах).

ӨЛ II 1. саарал, цайвар толботой; *өл буурал хангай минь, өндөр болоод сүрлэг байна* (дуу); **өл буурал морь** (хөх буурал); 2. манхан, нэвт, туус; **өл халзан,** (туус нэвт халзан).

ӨЛ III хэюү, намхан, бяцхан даваа; *өл хөтөл; өлийн даваа нь цастайхан байна даа хөө* (дуу); **өл овоо** (хөтөл даваа дээр босгосон овоо).

ӨЛБӨЛЗӨХ 1. байн байн өлийж хялалзан харах; 2. идэш эрж ховдоглох, доншуучлан хэсэх, тэнэх.

ӨЛБӨЛЗҮҮЛЭХ өлбөлзөхийн үйлдүүлэх хэв.

ӨЛБӨРГӨХ өлбөрүүлэх.

ӨЛБӨРӨХ өлсөхийн туйлд хүрэх; *өлбөрч үхэх.*

ӨЛБӨРҮҮЛЭХ өлбөрөхийн үйлдүүлэх хэв.

ӨЛГИЙ 1. нялх хүүхдийг өлгийдөх, боодоллох хэрэгсэл *өлгийтэй хүүхэд; өлгийн дуу;* 2. шилжсэн төрсөн орон нутгийг энхрийлэн хэлнэ; *өлгий нутаг;* 3. өлөг, элэг, энгэр, ээвэр газар; 4. юмбүү; **өлгий алт** (нэг лан); **өлгий мөнгө** (тавин лан).

ӨЛГИЙДӨХ нялх хүүхдийг өлгийгөөр боох.

ӨЛГИЙДҮҮЛЭХ өлгийдөхийн үйлдүүлэх хэв.

ӨЛГИЙЛӨХ өлгийдөх.

ӨЛГӨГДӨХ өлгөхийн үйлдэгдэх хэв; *модонд өлгөгдөх шахав.*

ӨЛГӨМӨЛ өлгөж хийсэн нь; **өлгөмөл шиш** (гоймон).

ӨЛГӨӨСТЭЙ өлгөөтэй.

ӨЛГӨӨТЭЙ өлгөсөн юм; өлгөөстэй; *толь өлгөөтэй байна.*

ӨЛГӨР дээш цоройсон, өлийсөн нь; *өлгөр толгойтой.*

ӨЛГӨХ 1. зүүх, дүүжлэх, дүүжлэн торгох; *хазаараа ханын толгойд өлгөв; малгай дээлээ өлгүүрт өлгөх;* 2. урт нарийн юмны үзүүр мэтээр өргөж авах; *морин дээрээс ташуураараа өлгөн авах;* 3. уургыг тавилгүй хуйвийг адууны толгойд углан уургалах; 4. шилжсэн өгсөх; *уулын ам өвд өлгөх;* 5. шилжсэн төлөвийг сонгож шилэх; *эдгээрийн дотроос өлгөж авах нь энэ л байна;* 6. шилжсэн бусдын үг яриаанаас ноцтойгий нь цохож зааж хэлэх; *үг өлгөх.*

ӨЛГӨЦ нийт нэг сэдэв бүхий үзэгдлүүдийн тухай товч мэдэгдэл; *утга зохиолын өлгөц; олон улсын өлгөц.*

ӨЛГӨЦӨӨ шагаа шүүрч наадах тоглоом; *өлгөцөө өлгөцөх* (шагаа шүүрэх).

ӨЛГӨЦӨХ шагаа шүүрч наадах.

ӨЛГҮЙ хоол тэжээлгүй, өлөн; *өлгүй хоносон морь.*

ӨЛГҮҮЛЭХ 1. өлгөхийн үйлдүүлэх хэв; 2. өлгөгдөх.

ӨЛГҮҮР 1. юм хумыг өлгөх, дүүжлэх хэрэгсэл; *махны өлгүүр; хувцасны өлгүүр;* 2. хуучирсан эхнэр хүний татуургын шаная орчмоос унжуулах чимэг; *өлгүүр зэмэг.*

ӨЛДӨӨХ өлдөхийн үйлдүүлэх хэв, өлдөхөд хүргүүлэх.

ӨЛДӨХ I хоол тэжээл холдох буюу дутаж доройтох; *морь өлдөөд явж өгөхгүй байна.*

ӨЛДӨХ II хэтэрхий сул, холхи болох; *өлдөөд сугарч ойчоод байх юм.*

ӨЛДҮҮЛЭХ өлдөхийн үйлдүүлэх хэв.

ӨЛЗИЙ I ээл, ивгээл, сайны хувь; **өлзий болох** (сайн тохиол болох); **өлзийгөө өгөх** (ивгээлтэй, азтай сайн байх); **өлзий бус** (сайны хувьгүй, хөнөөлтэй, харш); **еэ өлзий бус!** (муушаан дуу алдах үг); **өлзий хутаг** (сайныг ирүүлэх хувь, зол жаргалан, энх жаргалан).

ӨЛЗИЙ II энх жаргалангийн хээ; *өлзий утас; өлзий зурах; давхар өлзий; тумэн өлзий.*

ӨЛЗИЙГҮЙ I гай гамшигтай, сайны хувьгүй.

ӨЛЗИЙГҮЙ II өлзий хээгүй.

ӨЛЗИЙГҮЙДЭХ хэтэрхий өлзийгүй болох.

ӨЛЗИЙЛӨХ хорлол хөнөөлгүй болон тайвшрах; **чоно нохой өлзийлөх** (малд хор хөнөөл хүргэхгүй өнгөрөх).

ӨЛЗИЙТЭЙ I ээлтэй, ивгээлтэй, хор хөнөөлгүй, тайван; *чоно ойрынхдоо өлзийтэй хуу ч.*

ӨЛЗИЙТЭЙ II өлзий хээ бүхий.

ӨЛЗИЙХҮҮ мануухайн цээрлэсэн нэр.

ӨЛИЙЛГӨХ өлийхийн үйлдүүлэх хэв, өлгөр болгох.

ӨЛИЙХ хүзүүг сунган толгой гэдрэг өргөх; *хоолойгоо өлийж товчоо товчлуулав.*

ӨЛЛӨХ I өл авах; *морио өллөх.*

ӨЛЛӨХ II өл газраар явах.

ӨЛМИЙ I 1. хөлийн тавхайн урд хэсэг; *өлмий дээрээ зогсох;* 2. гутлын улны урд хэсэг; *гутлын өлмий* 3. хөлийн хүндэтгэл.

ӨЛМИЙ II хоёр буюу түүнээс дээш үеэс бүтсэн шүлгийн давтах нэгж.

ӨЛМИЙДӨХ өлмийгөөс барих; *өлмийдөж унагаах.*

ӨЛМИЙДҮҮЛЭХ өлмийдөхийн үйлдүүлэх хэв.

ӨЛМИЙЛДӨХ 1. өлмий дээрээ гишгэх, зогсох; 2. бөхийн мэх өлмийгөөр гохдох.

ӨЛМИЙЛДҮҮЛЭХ өлмийлдөхийн үйлдүүлэх хэв.

ӨЛМҮҮ: **өлмүү зөлмүү** мөчүү тачуу, дөнгөж хүрч бололцох төдий, мөчиг тачиг.

ӨЛӨГ I өвдөөд байх эвэршилгүй бөгөөтлөө доройтох өвчин; *өлөг өвчин тусах.*

ӨЛӨГ II 1. түүхий эд; *арьс шир зэрэг өлгийн зүйл;* **эд өлөг** хорш.; 2. булшнаас гарсан эд агуурс зэрэг олбор, эд өлгийн зүйл.

ӨЛӨГТӨХ өлөг өвчин тусах.

ӨЛӨГЧИН нохой зэрэг зарим араатан амьтны эмэгчин; *өлөгчин нохой; өлөгчин барс; өлөгчин чоно.*

ӨЛӨЛЗӨХ өлс өлс хийх.

ӨЛӨЛЗҮҮЛЭХ өлөлзөхийн үйлдүүлэх хэв.

ӨЛӨМ: өлөм шөлөмгүй өнгө жавхаагүй, зэвхий хужгар царайтай; *өлөм шөлөмгүй зэвхий цагаан царайтай хүн.*

ӨЛӨН I 1. хоол тэжээл идээгүй, гэдэс хоосон; **өлөн элгэн дээрээ эм уух** (өглөө босоод юм идэлгүй эм уух); *өлөн бие дээрээ; өлөн явах; өлөн морь;* ☆ **өлөн гэдэс** (амьтны нарийн гэдэс); **өлөн зуд** (идэш чухаг цаг); **өлөн ховдог** (ховдог хомхой); 2. шилжсэн нарийн, нимгэн, өчүүхэн төдий; **өлөн шороо** (нарийн тоос шороо); **өлөн хир** (нарийн хир); **өлөн өргөс** (маш нарийн өргөс): **өлөн нүд** (гярхай нүд).

ӨЛӨН II ургамал намаг чийгтэй газар ургадаг ургамал, иш гурван талтай, навч нарийн, цэцэг баг багаар ургана, хавар эрт цэцэглэнэ, төрөл зүйл олон; *өлөнгийн төрөл; намгийн өлөн; голын өлөн;* **өлөн сахал** ургамал (дугтуйлан ургасан жижиг хайрст навчтай бүрхүүлтэй ургамал, цахилдагтай адилавтар, сөөхий гуталд дэвсдэг); **өлөн хутгуур** амьтан (чийгтэй газар төрнө, цууцлайтай адил бөгөөд том, толгой жигүүр сүүл цөм бараан, өвчүү цагаан нэг зүйл шувуу); *өлөн өвс ургасан газар тариа бүү тарь, үгэндээ эзэн болохгүй хүнтэй арилжаа бүү хий* зүйр.

ӨЛӨНГӨ I ургамал хөхөвтөр ногоон навчтай, түрүү нь унжуу, цэцгийн доод хэсэг үстэй, 60—80 сантиметр өндөр бут бутаар ургадаг ургамал, адуу идэх дуртай.

ӨЛӨНГӨ II гэдэс хоосон, өлөн.

ӨЛӨНГӨТГӨХ өлөнгөтөхийн үйлдүүлэх хэв.

ӨЛӨНГӨТӨХ гэдэс хоосдох, өлсөх.

ӨЛӨРХӨХ өлсч өл хоол эрэх.

ӨЛӨХ өлүүрээр хөшиж өргөх.

ӨЛСГӨЛӨН ган зуд зэрэг гай гамшгийн уршгаар идэх хэрэглэх юм олдохгүй болох хүнд байдал; *өлсгөлөн болох;* **өлсгөлөн зарлах** (эсэргүүцлийн тэмдэг болгож хоол идэхээс татгалзах).

ӨЛСГӨХ өлсөхийн үйлдүүлэх хэв.

ӨЛСӨӨХ өлсүүлэх, өлсөхөд хүргүүлэх.

ӨЛСӨХ 1. хоол тэжээл хэрэглэх, шаардахыг мэдрэх; *гэдэс өлсөх; хэд хоног хоол идээгүй өлсч явав; өлсөхөд өл бугын эвэр зөөлөн, цадахад цагаан хурганы мах хатуу* з ү й р; 2. ш и л ж с э н ногоо зэргийн ус хатаж агших, шуумайх; *манжин өлсөх; алим өлсөх.*

ӨЛСҮҮЛЭХ өлсөхийн үйлдүүлэх хэв, өлсөхөд хүргүүлэх.

ӨЛҮҮЛЭХ өлөхийн үйлдүүлэх хэв.

ӨЛТӨГ өртөг.

ӨЛТӨГЛӨХ үнэлэх.

ӨЛҮҮР юмыг гөнжиж хөшин өргөх зэвсэг.

ӨЛХӨН I 1. уужимхан, сул, элбэг, боох хавчихгүй; *өлхөн багтах;* 2. ш и л ж с э н хялбархан, амархан, их хүчдэлгүй; *өлхөн дөнгөж орхив.*

ӨЛХӨН II 1. өлөн мэт, өлөндүү; **өлхөн цадах** (дутуу цадах); 2. ш и л ж с э н дутуу, дутмаг; **өлхөн унтах** (дутуу, бага унтах).

ӨЛЧИР хүйтэнд авсаар даардаггүй тэсвэртэй; *өлчир хүн.*

ӨЛЧИРЛӨХ өлчир болох, хүйтэнд тэсвэрлэх.

ӨМ I цөм, эмт, сэт; *өм хазах; өм эчих; өм татах; өм түлэгдэх;* **өм цөм** х о р ш..

ӨМ II: **өм цэрэг** жанжны бие хамгаалах цэрэг.

ӨМБҮҮ үхрийн мөөрөх аялга; *манай хар үнээ өмбүү өмбүү гэж мөөрөв.*

ӨМГӨЛЗӨХ өмөлзөх.

ӨМГӨНӨХ өмөг өмөг хийх.

ӨМГӨӨЛӨГЧ 1. гэмт хэрэг үйлдсэн хүнд ял унагаахад хууль зүйг баримтлан шүүмжилж хөнгөтгөхийг эрэн хэлэлцэгч хүн; *хэрэгтний өмгөөлөгч;* 2. хамгаалагч этгээд.

ӨМГӨӨЛӨЛ өмгөөлөх үйлийн нэр, хамгаалал.

ӨМГӨӨЛӨХ өмөөрөх, хаацайлан хамгаалах; *өмгөөлж хамгаалах.*

ӨМГӨӨЛҮҮЛЭХ өмгөөлөхийн үйлдүүлэх хэв.

ӨМГӨР дэндүү жаахан, бага, умгар; *өмгөр амтай лонх; өмгөр гэр; ийм өмгөр саванд юу багтах вэ.*

ӨМД биеийн доод хэсгийг бүслэхий хүртэл бүрхэх салтаатай хувцас; *гадуур өмд; дотуур өмд; урт өмд; өмдний тэлээ; өмдний шудмаг; өмдний гуя; өмд хийж өгөх хүнгүй болович өмчий нь идэх төрөлтэй* х у у ч.

ӨМИЙЛГӨХ өмийхийн үйлдүүлэх хэв.

ӨМИЙХ өмгөр болох; *өмийсөн амтай сав.*

ӨМЛӨХ өмрөхөд хүргэх, өм татах; *ирмэгээс нь өмлөн авч үзэв.*

ӨМЛҮҮЛЭХ өмлөхийн үйлдүүлэх хэв.

ӨМНӨ 1. урд зүг; *өмнө зүгийн халуун орон; баруун өмнө; зүүн өмнө; өмнө хойно;* 2. өвөр тал; *өмнө нь нэг ном дэлгээстэй байв; гэрийн өмнө;* 3. нүүр, урд талд; *даргын өмнө номхон зогсож байв; олны өмнө хэлэх; хүний нүдний өмнө;* **өмнө хойно нь явах** (ажил явдлы нь бүтээж явах); 4. тулгам; *бидний өмнө зогсож байгаа нэг чухал зорилго бол өвс хадлангийн ажил байна;* **юуны өмнө** (юм, юмнаас урьд); 5. ш и л ж с э н урьд, тэргүүнд; *өвөл болохын өмнө; одоогоос хоёр жилийн өмнө; илтгэл хийхийн өмнө; хоолны өмнө; өмнө хойногүй нэгэн зэрэг.*

ӨМНӨД урд дахь, урд зүгийн; **өмнөд туйл** (дэлхийн бөмбөрцгийн өмнөд хязгаар).

ӨМНӨӨ өөр, ондоо; *жил болсны дараа үзэхэд их л өмнөө болсон байна; энэ гурваас өмнөө хүн байна уу?*

ӨМНӨӨЛӨХ өөр ондоо болгох, тусгаарлах.

ӨМНӨӨЛҮҮЛЭХ өмнөөлөхийн үйлдүүлэх хэв.

ӨМНӨӨС 1. өмнийн ,урдаас; *өмнөөс умар одох;* 2. өвөрөөс; *өмнөөс харах;* 3. өөдөөс; *өмнөөс нь ирж явав; чамд даргынхаа өмнөөс эсэргүүцэх толгой байна уу?* 4. төлөөнөө, төлөөнөөс; *ах нь дүүгийнхээ өмнөөс барилдав;* 5. үүднээс; *хорлох санааны өмнөөс өдөөсөн асуудал.*

ӨМНӨХ 1. өмнө нь байгаа, урдахь, урд зүгийн; *өмнөх орны ургамал;* 2. урд нь байгаа; *өмнөх хүндээ хэлэв;* **өмнөх тайз** (тайзны өмнөх хэсэг); 3. ш и л ж с э н урьдах, тэргүүний; **өмнөх үгүүлэл** (удиртгал).

ӨМӨГ харгалзаж хамгаалах түшиг, тулгуур; **өмөг түшиг** х о р ш.; *өмөг түшиг болох;* **өмөг садан** (төрөл садан).

ӨМӨГЛӨГЧ өмгөөлөгч, өмөөрөгч, хамгаалагч.

ӨМӨГЛӨХ өмөөрөх, өмгөөлөх, хамгаалах.

ӨМӨГЧ хэтэрхий өмөглөх зантай.

ӨМӨГЧЛӨХ өмөглөх.

ӨМӨГШИХ өмөглөх.

ӨМӨЛЗӨХ 1. өмгөр юмны өмөг өмөг хөдлөх; 2. юмны ам амсар өмийх; *уруул нь өмөлзөв, уйлах нь.*

ӨМӨЛЗҮҮЛЭХ өмөлзөхийн үйлдүүлэх хэв.

ӨМӨН хорт хавдар, бадгана; *ходоодны өмөн;* **өмөн үү** (хорт хавдар өвчний нэг зүйл).

ӨМӨӨЛӨХ өмгөөлөх, өмөөрөх, хамгаалах.

ӨМӨӨРӨГЧ өмөглөгч, өмгөөлөгч, хамгаалагч.

ӨМӨӨРӨХ өмгөөлөх, өмөглөх, хамгаалах, хаацайлах; *биеэ өмөөрөх; дүүгээ өмөөрөх.*

ӨМӨӨРҮҮЛЭХ 1. өмөөрөхийн үйлдүүлэх хэв; 2. өмөөрөгдөх.

ӨМӨӨРӨГДӨХ өмөөрөхийн үйлдэгдэх хэв.

ӨМӨӨЧЛӨХ 1. өмөглөх, өмгөөлөх, дотночлох; 2. гоёчлох, засдаглах.

ӨМӨРХИЙ өм өм гэмтсэн, эмтэрсэн, урагдсан нь:**өмөрхий цөмөрхий** х о р ш..

ӨМРӨХ эмтрэх, сэтрэх, өм үсрэх; *түлэгдээд өмрөн унав.*

ӨМРҮҮЛЭХ өмрөхийн үйлдүүлэх хэв.

ӨМСГӨЛ өмсдөг юм; *бөхийн өмсгөл.*

ӨМСГӨХ өмсүүлэх, өмсөхөд хүргүүлэх.

ӨМСӨХ хувцас хунарыг биед хувцлах; *дээл өмсөх; гутал өмсөх; малгай өмсөх.*

ӨМСҮҮЛЭХ өмсөхийн үйлдүүлэх хэв.

ӨМСХИЙХ 1. гэнэт өмийх, баахан өмийх; *уруул нь өмсхийв;* 2. дуугүй гэнэт инээх.

ӨМХ ялзарч зөөлөн, сэвсгэр болсон нь; *өмх мод; өмх түлээ утаа ихтэй, өгөр тэрэг хахинаа ихтэй* з ү й р.

ӨМХИЙ 1. нялуун, нигшүүн муухай үнэр; *өмхий үнэр;* **өмхий ховол** у р г а м а л (бут бутаар ургана, гол нь их, навч тоорын модны адил болоод их нэг зүйл мод); **өмхий нүцгэн ховол** у р г а м а л (нүцгэн ховлын адил болоод навч өмхий нэг зүйл мод); **өмхий тон мод** у р г а м а л (навч гарын алганы адил, гурван уулзартай, зулгарахгүй, үнэр өмхий нэг зүйл мод); **өмхий бэхлиг мод** у р г а м а л (дурс бүдүүн ширүүн, мах судал хөөслөг, сав хийвэл болдог, нүцгэн ховлын нам нэг зүйл мод); **өмхий хүрэн** у р г а м а л (уруул цэцгийн язгуурын олон наст ургамал, жижигхэн хар хөх цэцэгтэй, үнэр эхүүн); **өмхий өвс** у р г а м а л (гол төлөв элс сайр, марзтай газар ургадаг, өмхий үнэртэй, олон наст ургамал, навч нарийн); **өмхий цох** а м ь т а н (нуруундаа хальстай, нэг зүйл хорхой); **өмхий хүрнэ** а м ь т а н (суусрын язгуурын араатан амьтан, үнэр өмхий, арьсыг хэрэглэнэ); 2. ш и л ж с э н далд, ёгт, зэвүүн; *өмхий үгээр утах; өмхий санаа гаргах; үгээгүү айлаас эрдэмтэн гарна, өмхий шавраас лянхуа дэлгэрнэ* х у у ч.

ӨМХИЙРӨХ өмхий болох; *мах өмхийрөх.*

ӨМХИЙРҮҮЛЭХ өмхийрөхийн үйлдүүлэх хэв.

ӨМХРӨХ ялзарч муудах, өмх болох; *өмхөрсөн хайс; мод өмхрөх.*

ӨМХРҮҮЛЭХ өмхрөхийн үйлдүүлэх хэв.

ӨМЧ 1. ямар нэгэн этгээдэд ногдсон зүйл, хувьд ногдсон зүйл; **өмч хувь** х о р ш.: *улсын өмч; нийгмийн өмч; нэгдлийн өмч; хоршооллын байгууллагын өмч;* 2. хувийн хөрөнгө; *өмч хуваах; өмч булаалдах; өмч салгах;* **өмчийн хөрөнгө** (хувийн хөрөнгө).

ӨМЧИРХӨГ өмчирхөх зантай, өмчирхүү.

ӨМЧИРХӨХ юмыг өөрийн өмч гэж хэтэрхий харамнах; *морио өмчирхөөд аваад явжээ.*

ӨМЧИРХҮҮ өмчирхөг зантай.

ӨМЧИРХҮҮЛЭХ өмчирхөхийн үйлдүүлэх хэв.

ӨМЧИХ I. өм үсрэх; 2. өм өм татах.

ӨМЧЛӨХ хувийнх болгох, өмч болгох; *өмчилж өгсөн хөрөнгө; өвчилж авах.*

ӨМЧЛҮҮЛЭХ өмчлөхийн үйлдүүлэх хэв, өмч эзлүүлэх.

ӨМЧҮҮЛЭХ өмчихийн үйлдүүлэх хэв.

ӨН цагийн сайн улирал; *энэ жил өн болох нь;* **өнтэй өвөл** (зудгүй, дулаан өвөл).

ӨНГИЙЛГӨХ 1. өнгийхийн үйлдүүлэх хэв; 2. өнгийх үйлийг биедээ хүлээх.

ӨНГИЙМ өнгийсөн хэлбэртэй юм; *өнгийм хад.*

ӨНГИЙМӨЛ өнгийсөн юм; *өнгиймөл мод.*

ӨНГИЙХ 1. юмны дээрээс шагайж харах; *хашаа дээгүүр өнгийх; тотгон дээгүүр өнгийх; тооноор өнгийх; хажуугийн хүний дэвтэр рүү өнгийх*; 2. давж орох; *дээвэр дээгүүрээ өнгийж байна;* 3. халдах, өдөх, довтлох, шунах; *өнгийн халдах.*

ӨНГӨ (Н) 1. аливаа юмны зүс, будаг, гэрлийн ялгавар; *хурц өнгө; будэг өнгө; хүрэн өнгөтэй ширээ; олон өнгийн будаг; өнгө өнгийн харандаа;* **өнгө буурах** (зүс, будаг муудах, гандах, гутах); **өнгө орох** (а. өнгө зүс сайжрах; *гуулин таваг арчаад байсан нь жигтэй сайхан өнгө оров;* б. царай зүс, жавхаатай болох); **өнгө алдах** (а. зүс будаг нь гутаж гандах; б. царай зүс, жавхаа муудах); **өнгө өнгийн** (а. олон өнгийн; б. олон зүсмийн); 2. юмны гадар тал; *бороонд газрын өнгө нилээд нэвтэрчээ; өнгөн тал; бөсийн өнгө; өнгийг гадагш нь харуулж хийх; дээлийн өнгө; дэвсгэрийн өнгө хийх бөс;* ☆ **өнгө нэхий дээл** (өнгө татаагүй хийсэн дээл); 3. үзэмжтэй, сайн, чанарлаг; *өнгөтэй торго; өнгө сайтай; өнгөтэй, өөдтэй юмаа аваад явлаа;* 4. зүс, царай; *өнгө мөнгөнд шунах; өнгөн дээрээ магтах; өрөнд унавал үгийрнэ, өнгөнд унавал үхнэ* хуучн; ☆ **өнгөний өвчин** (голдуу хурьцлын явдлаар халдах халдварт өвчин); 5. шилжсэн янз, байдал; *үгний өнгө; хэргийн өнгө.*

ӨНГӨГҮЙ I. заах өнгө байхгүй; *өнгөгүй шингэн зүйл;* 2. шилжсэн жавхаа муутай; 3. гадар үгүй.

ӨНГӨЛЗЛӨГӨӨ өнгөлзөх үйлийн нэр; *дайсны өнгөлзлөгөө.*

ӨНГӨЛЗӨГЧ өнгөлзсөн этгээд.

ӨНГӨЛЗӨМТГИЙ байн байн өнгөлзөх зантай, өнгөлзөмхий.

ӨНГӨЛЗӨМХИЙ өнгөлзөмтгий.

ӨНГӨЛЗӨХ 1. байн байн өнгийх; 2. шилжсэн атаархан харах; 3. дайрах, довтлох, халдах; *өнгөлзөх дайсны өрий нь өшиглөх.*

ӨНГӨЛЗҮҮЛЭХ өнгөлзөхийн үйлдүүлэх хэв.

ӨНГӨЛЗҮҮР 1. өнгөлүүр; 2. өнгөлзөмтгий.

ӨНГӨЛМӨЛ өнгөлсөн юм.

ӨНГӨЛӨГДӨХ өнгөлөхийн үйлдэгдэх хэв.

ӨНГӨЛӨХ 1. өнгө сайтай болгох; *зүлгэж өнгөлөх; төмөр өнгөлөх;* 2. шилжсэн хуурмаг зан гаргах, мэхлэх, баширлах; *өнгөлж ярих;* 3. өнгө гадар хийх; *дээл өнгөлөх.*

ӨНГӨЛҮҮЛЭХ 1. өнгөлөхийн үйлдүүлэх хэв; 2. өнгөлөгдөх.

ӨНГӨЛҮҮР I өнгөлзүүр, хоолойн доод, будэрхийн дээдхэн байгаа хөнхөр газар.

ӨНГӨЛҮҮР II юмыг өнгө оруулах зэвсэг.

ӨНГӨР чийгтэй юм дээр наалдаж тогтох наалдаа; *хэлний өнгөр; хөхүүрний өнгөр.*

ӨНГӨРГӨХ өнгөрүүлэх, өнгөрөхөд хүргүүлэх.

ӨНГӨРГҮЙ 1. өнгөр байхгүй 2. шилжсэн харамч, бусдад тус хийдэггүй; **гэдэс өнгөргүй болох** (дотор муудах).

ӨНГӨРЖИХ өнгөртэй болох.

ӨНГӨРӨГЧ 1. өнгөрсөн нь; *өнгөрөгч хавар;* 2. нас нөгчигч, талийгаач.

ӨНГӨРӨӨХ өнгөрүүлэх, өнгөрөхөд хүргүүлэх.

ӨНГӨРӨХ 1. дэргэдүүр ,хажуугаар яван гарах; *энэ өнгөрч яваа галт тэргийг хар; би өнгөрье, дараагаар нь чи гар;* 2. бороо салхи зэрэг байгалийн үзэгдэл дайран гарах; *үер өнгөрөв; салхи өнгөрөв; жил өнгөрөх гэж байна, төлөвлөгөө яагаа ч үгүй байдгийн шалтгаан юу вэ?* 3. хэтрэх, давж цааш гарах; *шөнө явсан тул буудлаас өнгөрч орхижээ; битгий өнгөрөөд явчихаарай!* 4. нас нөгчих; *өвөг эцэг нь урьд шөнө өнгөрчихжээ;* ☆ **өнгөрсөн борооны хойноос цув нөмөрнө** хууч. (аливаа юмыг цаг хожимдуулан үйлдэх); **өнгөрсөн цаг** (тухайн үйлийн болж дууссаныг заах төгс үйл үг).

ӨНГӨРТӨХ өнгөр тогтох; *хөхүүр өнгөртжээ; хэл өнгөртөх.*

ӨНГӨРҮҮ хэтэрхий, давуу, хэтрүү; *үр ачаар цухаг байсан, өнгөрүү ванлий заяажээ* (дуу).

ӨНГӨРҮҮЛЭХ 1. өнгөрөхийн үйлдүүлэх хэв; 2. уучлах, хэлтрүүлэх, хэтрүүлэх; *энэ нэг удаа өнгөрүүлье дээ! цаг өнгөрүүлэх хугацаа өнгөрүүлэх.*

ӨНГӨРШИЙХ 1. өнгөртөх, өнгөржих; 2. шилжсэн юманд ханангүй, харам багатай болох.

ӨНГӨСХИЙХ I өнгөрөх, хэтрэх.

ӨНГӨСХИЙХ II гэнэт өнгийх.

ӨНГӨТЭЙ өнгө бий, өнгө сайтай, гоёмсог; *ямар өнгөтэй юм бэ? өнгөтэй хувсаа өмс!.*

ӨНГӨЦ I гудас, өнгө татсан нарийвтар дэвсгэр; *орны өнгөц.*

ӨНГӨЦ II 1. нимгэн, хөнгөн, дээгүүр, дөнгөж өнгөн дээрх; *өнгөц түрхэх; өнгөц будах;* 2. гүн биш, лав биш; *өнгөц шарх;* 3. шилжсэн хуурмаг, башир; *өнгөц зан; өнгөц сониуч.*

ӨНГӨЦХӨН 1. өнгөн дээрх нимгэн; 2. гүн, лав биш; 3. хуурмаг, башир; *өнгөцхөн зан гаргах.*

ӨНГӨЧ 1. гоё, ганган; 2. шилжсэн зусарч, бялдууч.

ӨНГӨЧЛӨХ өнгөч зан гаргах.

ӨНГӨШРӨХ будах арчих тэргүүтэнд өнгө орох, өнгө шингэх.

ӨНДГӨВЧ эмийн бэлгэсийн өндгөн эс бүрэлдүүлэх эрхтэн.

ӨНДГӨРХҮҮ өндөг шиг хэлбэртэй.

ӨНДИЙЛГӨХ өндийхийн үйлдүүлэх хэв; *толгой өндийлгөх.*

ӨНДИЙХ баахан дээшээ болох, өөдөө болох; *цээж нь өндийв; босохоор өндийх.*

ӨНДӨГ I 1. шавьж, хоёр нутагтан, мөлхөгчид, жигүүртний эр эм билгийн эсээс бүрэлдсэн үржлийн үр; 2. шувууны мөн тийм эсээс бүрэлдсэн гадуураа хальстай зууван хэлбэртэй бөөрөнхий зүйл; **өндөгний хальс** (өндөгний хатуу бүрхүүл): **өндөгний уураг** (өндөгний шингэн зүйл); **өндөгний зулам** (өндөгний хатуу хальсны дотоод нимгэн хальс); **өндгөн мөөг** ургамал (хогт дарагдсан, ялзарсан модны тушаа ургах, орой нь цагаавтар, дотроо бараахан мөөг); **өндгөн хэв** (буудайн гурилд тахианы өндөг чихэр хоршиж тостой хийсэн боорцог); **өндөгний хагсмал бин** (жигнэсэн буудайн гурилд өндөг чихэр хоршин хийж хайрсан бин); **өндгөн сүй** хуучирсан (а. эцэг эх нь хөвгүүн охиноо эхийн хэвэлд байхад буюу нялх бүхийд нь хожим эр эм болгон холбохоор хэлэлцэн тогтсон хэлэлцээр; б. хожим эр эм богтлоход эрийн талаас эхнэр болгох хүний эцэг эхэд анх удаа очиж хадаг тавих); *өндөгнөөс яс эрэх, өвхнөөс шөрмөс эрэх* хууч.

ӨНДӨГ II эр эм бэлэг ойртож үр суусны дараа шинэ махбод үүсгэх эс.

ӨНДӨГ III хурууны үзүүрийн өвөр этгээдийн зөөлөн бэлцгэр хэсэг; *хурууны өндөг;* **өндөг дарам** (хурууны өндөгний хир хэмжээтэй).

ӨНДӨГЛӨГ өндөг хэлбэртэй.

ӨНДӨГЛӨХ өндөг төрөх амьтны өндөг гаргах, төрөх; *тахиа өндөглөх.*

ӨНДӨГЛҮҮЛЭХ өндөглөхийн үйлдүүлэх хэв.

ӨНДӨЛЗӨХ байн байн өндөс өндөс хийх.

ӨНДӨЛЗҮҮЛЭХ өндөлзөхийн үйлдүүлэх хэв.

ӨНДӨР 1. дээш доошоо их, урт; *өндөр байшин; өндөр хүн; өндөр уул;* **өндөр хавьс** (дөрвөн өндөр хавирга); **өндөр шар бударгана** ургамал (говь, говирхуу газар өндөр ургадаг нэг зүйл бударгана); **өндөр удвал цэцэг** ургамал (иш нэг хос алд илүү, навч олсны навчтай адилхан, цэцэг пял мэт их, өнгө шар нэг зүйл удвал цэцэг); 2. их, үлэмж; **нас өндөр болох** (өвгөрөх, хөгшрөх); **өндөр жил** (сарны зурхайн илүү сартай жил, нарны зурхайн 366 хоногтой жил); **өндөр үнэлэх** (дээд зэргээр үнэлэх); 3. дээд; *өндөр эмээ; өндөр өвөг; өндөр заяа;* 4. чанга; *өндөр дуугаар хашгирах; өндөр уул чулуугаараа, ургаа мод үндсээрээ* зүйр.

ӨНДӨРДӨХ хэтэрхий өндөр болох; *багана нь өндөрдсөн майхан.*

ӨНДӨРДҮҮЛЭХ өндөрдөхийн үйлдүүлэх хэв.

ӨНДӨРЛӨГ өндөр газар нь; *Алтайн ноёлох өндөрлөг дээр гарах.*

ӨНДӨРЛӨХ 1. өндөр болгох; 2. шилжсэн найр хуримын төгсгөл тарах; *найр өндөрлөх.*

ӨНДӨРЛҮҮЛЭХ өндөрлөхийн үйлдүүлэх хэв.

ӨНДӨРСГӨХ ендөр болгох, өндөрсүүлэх.

ӨНДӨРСӨХ өндөр болох.

ӨНДӨРТГӨХ өндөрсгөх, өндөр болгох.

ӨНДӨРТГҮҮЛЭХ өндөртгөхийн үйлдүүлэх хэв.

ӨНДӨРТӨХ улмаар өндөр болох.

ӨНДӨРТҮҮЛЭХ өндөртөхийн үйлдүүлэх хэв.

ӨНДӨРХӨН баахан өндөр.

ӨНДӨСХИЙЛГЭХ өндөсхийхэд хүргүүлэх, өндөсхийхийн үйлдүүлэх хэв.

ӨНДӨСХИЙХ түр өндийх, давхийн өндийх; *өндөсхийн босох.*

ӨНЖИЛГӨН: **өнжилгөн хусран** жил өнжиж төрөх мал; *өнжилгөн үнээ; өнжилгөн гүү.*

ӨНЖИХ 1. нэг өдрийг өнгөрүүлэх, алгасах; *өнжөөд нэг удаа; хоёр өнжөөд явав;* **хонон өнжин** х о р ш.; *гэртээ өнжих;* 2. алгасах, өнгөрүүлэх; *жил өнжөөд тугаллах; тариа тарихгүй өнжих.*

ӨНЖМӨЛ жил өнжсөн нь; *өнжмөл дэлтэй морь; өнжмөл идээ.*

ӨНЖӨӨХ өнжүүлэх, өнжихөд хүргүүлэх.

ӨНЖРӨГ өдлөж засаагүй сумны мод, үүсгэр.

ӨНЖҮҮЛЭХ өнжихийн үйлдүүлэх хэв.

ӨНӨ 1. эрт; **өнө эртийн** (маш эртний); 2. удаан; **өнө удаан** (маш удаан); **өнө болох** (удах).

ӨНӨД үүрд; **өнөд бат** (үүрд бат).

ӨНӨЖИХ өнө болох.

ӨНӨӨ 1. одоо, мөнөө; **өнөө цагт** (одоо цагт); **өнөө саяхан** (мөнөө саяхан); 2. **өнөөдөр** мөн өдөр. энэ өдөр; **өнөө, маргаашгүй** (тун удахгүй, хэзээ хэзээгүй); 3. **өнөөх**, нөгөө, мөнөөх; *өнөө хүн маань энэ; өнөө бичгээ аль.*

ӨНӨӨДӨР мөн өдөр, энэ өдөр; *өнөөдөр бол цагаан сарын шинийн нэгний өдөр; өнөөдрийн хурал дээр.*

ӨНӨӨДӨХГҮЙ их л яарсан байдал; *өнөө өнөөдөхгүй хэрэгтэй байна.*

ӨНӨӨДҮҮЛ нөгөөдүүл; *өнөөдүүлийг хүлээхээс өөр аргагүй болов; өнөөдүүлдээ хэлээрэй.*

ӨНӨӨТӨХ нөгөөдөх; *өнөөтөх алдсан морь чинь говьд явж байна гэнэ.*

ӨНӨӨХ заах төлөөний үг, өнөө, мөнөө, нөгөөх; *өнөөхийгөө хэлж өг! өнөөх чинь ирсэн; өнөөхөөсөө асуугаач; өнөөх явдал; өнөөх дуугаа дуул! өнөөхийгөө аваад ирээрэй.*

ӨНӨӨХӨН мөнөөхөн, саяхан.

ӨНӨР төрөл садан, ах дүү олуул; *өнөр гэр бүл; өнөр олон.*

ӨНӨРДӨХ хэтэрхий өнөр болох, олдох.

ӨНӨРЖИХ өнөр болох.

ӨНӨРЖҮҮЛЭХ өнөржихийн үйлдүүлэх хэв.

ӨНӨРШИХ өнөрийн шинжтэй болох.

ӨНХРӨХ 1. хөлбөрөх, орчих, бөмбөрөх; *бөмбөг өнхрөх; хамхуул хийсч өнхрөх; хүүхэд зүлэг дээгүүр өнхрөн наадаж байв;* 2. ойчих, унах; *өнхөрч ойчих.*

ӨНХРҮҮЛЭХ 1. өнхрөхийн үйлдүүлэх хэв; 2. ш и л ж с э н худалдаа арилжаа хийх; *бага сага юм өнхрүүлж амьдарч байна.*

ӨНЦГӨРХҮҮ өнцөгтэй мэт.

ӨНЦӨГ 1. нэг цэгээс гарсан хоёр шугамын хоорондох хавтгийн нэгэн хэсэг, булан; **тэгш өнцөг** (90 градус): **хурц өнцөг** (90 градусаас доош); **мохоо өнцөг** (90 градусаас илүү); *гурвалжны гадаад, дотоод өнцгүүд;* 2. булан, сэжүүр; *ширдэгний өнцөг; ширээний дөрвөн өнцөг* 3. ш и л ж с э н **өө**, сэв; *өө өнцөг; үгний өө өнцөг андахгүй.*

ӨНЦӨГДӨХ өнцөг тохиолдох, тааралдах; **өнцөгдсөн суудал** (ширээний өнцөг тохиолдсон зохимжгүй суудал).

ӨНЦӨГДҮҮЛЭХ өнцөгдөхийн үйлдүүлэх хэв.

ӨНЦӨГЛӨГ өнцөг хэлбэртэй, өнцөг бүхий.

ӨНЦӨГЛӨХ юманд өнцөг гаргах.

ӨНЦӨГТЭЙ 1. өнцөг, булан бүхий; 2. ш и л ж с э н сүрхий, чадалтай, чадамгай, хэцүү, ноцтой; **өнцөгтэй нүд** (юмыг анзаарахдаа сүрхий нүд); **өнцөгтэй үг** (чадамгай үг).

өнцөгч өөнтөгч.

өнчдөх хэтэрхий өнчин болох.

өнчин 1. эцэг эхгүй эсвэл эцэг буюу эхгүй; *өнчин хүүхэд;* **өнчин өрөөсөн** хорш.; 2. эхийн тэжээж байх үед эхээс ангижирсан нь; *өнчин хурга;* 3. ганц, ганцаар; **өнчин мод** (ганцаар ургасан мод); **өнчин саримсаг** (хэлтэсгүй саримсаг); **өнчин элэг** (элэгний ганц бяцхан салбар); *өнчнийг өсгөвөл хүн болдог, өргөдгийг асарвал мал болдог* зүйр.

өнчрөх 1. өнчин болох; 2. өнчин учраас зовж зүдрэх, ганцаардах; *хөөрхий, тэр ихэд өнчирч байлаа.*

өнчрүүлэх өнчрөхийн үйлдүүлэх хэв, өнчрөхөд хүргүүлэх.

өө I 1. юмыг тэгш биш болгож байгаа зүйл; **өө сэв** хорш.; *өөгий нь дарах;* 2. бартаа; *замын өө анхаарч явах;* **замын өө** (бартаа чулуу зэрэг); 3. шилжсэн согог, гэм, буруутай тал, осол; *үгний өө; өө гаргах; өөтэй хүн; өө сэв эрэх;* **өө бохгүй** хуучирсан (учир шалтгаангүй).

өө II голох, гоморхох мэтэд хэрэглэх аялга; *өө, чи юүнд ингэж орхив; өө, ямар жигтэй юм бэ!.*

өөв 1. үхэр тугалыг дуудахад хэрэглэх аялга; *өөв өөв!* 2. бусдын дуудахад хариу өчихөд хэрэглэнэ; *өөв, юу гэнэ!.*

өөвгөр суурь муутай, тонгойж өцийсөн нь; *морин дээр яваа өөвгөр чинь хэн бэ?.*

өөвийх тогтвор муутай тонгойж өцийх; *гар нь бээрээд эмээл дээрээ өөвийж суув.*

өөвлөх 1. тугалаа голсон үнээнд тугалы нь авахуулахаар өөв өөв гэж аялгуулан дуулах; *үнээ өөвлөх;* 2. өөв гэж дуудах; 3. өөв гэж хариу дуугарах.

өөвлүүлэх өөвлөхийн үйлдүүлэх хэв.

өөг I 1. жийрэг, бамбай; *юм мөрлөхөд мөр дээрээ өөг тавих; хөмны дор өөг тавих;* 2. ус хаах хулсан, бургасан баглаа; *өөг халх.*

өөг II аялга; 1. хөөе; 2. хөөг.

өөглөх 1. өөвлөх; 2. шилжсэн эндүүрэн хэлэлцэх; 3. өөг тавих.

өөгүй 1. сэвгүй, хортонгүй; *өндөг шиг өөгүй;* 2. бартаагүй, тэгш; *өөгүй тал;* 3. шилжсэн ямар ч муушаах, голох зүйлгүй, маш сайн; *энэ хүний хийсэнд ямар ч өө алга байна; өөгүй эд;* **өөгүй хүн** (томоотой, сайн хүн); 4. шилжсэн осол, эндэгдэлгүй; *өөгүй явах.*

өөгших амтших, эрэмших; *даварч өөгших, эрэмшиж өөгших; тэгэх дутам улам өөгшиж байна.*

өөгшүүлэх өөгшихийн үйлдүүлэх хэв.

өөд 1. дээш; *өөдөө харах; уул өөд авирах;* 2. урд, өмнө, эсрэг зүг; *өөдөөс нь тосон очив; өөдөөс харах;* **өөдөө, сөөргөө явах** (нааш цаашаа явах); 3. шилжсэн хүндтэй газар, хоймор тал; *та өөдөө суугтун;* 4. шилжсэн олиг, сайн, сайжрах тал; **өөдтэй явах** (сайн амьдарч явах); **өөд нь татах** (сайжруулах, тэтгэх, дэмжих); 5. шилжсэн олиг, чадал, чанар; *өөдтэй хэлэх; өөдтэй харсангүйгээр ийм болов; өөд муутай; өөрийн хийсэн өөрт, өөдөө хаясан толгойд* зүйр; **өөд болох** (а. залрах; б. үхэх; в. дээшээ болох, суух).

өөдгүй олиггүй, сайн биш, муу; *өөдгүй амьтан; өөдгүй эд; өөдгүй зан гаргах.*

өөдлөх 1. дээш авирах, өгсөх, дээшлэх; 2. шилжсэн хөгжих, дэгжих, сайжрах; *өөдөлж яваа аж ахуй; өөдлөх айлын үг нь нэг, өсөх малын зүс нь нэг* зүйр; 3. *хуучирсан нас нөгчих, өөд болох.*

өөдлөхгүй сайжрахгүй, дэгжихгүй.

өөдлөшгүй өөдлөх, засрах төлөвгүй; *өөдлөшгүй муу этгээд.*

өөдлүүлэх өөдлөхийн үйлдүүлэх хэв.

өөдөн хилэн мэт нэхээстэй нөгөн зүйл торгомсог бараа.

өөдөө дээшээ, эх тийшээ.

өөдөөс өмнөөс, урдаас; *өөдөөс нь гарч ирэв; настай хүний өөдөөс дэмий юм ярих.*

өөдөс 1. юмны бяцхан хэсэг, юмнаас илүү гарсан тайрдас, хэлтэрхий, хугархай; *даавууны өөдөс; модны өөдөс;* 2. өчүүхэн, бяцхан; *өөдөс шиг амьтан.*

өөдтэй олигтой, дөмөг, арай илүү.

өөдтэйхэн олигтойхон; бузгайхан; *өөдтэйхөн хийх хэрэгтэй.*

ӨӨЕ бусдын дуудахад хариу өчих аялга; өөв.

ӨӨЛД 1. Монгол үндэстний нэг аймаг болох дөрвөн Ойрд гэгчийг хамтатган ийнхүү нэрлэнэ; *Өөлд ардын дуу;* 2. Монголын нэг овог.

ӨӨЛИЙ булиа, бадриун, ихээхэн биетэй; *өөлий хүүхэд; өөлий хурга.*

ӨӨЛӨХ 1. юмны өө сэвийг авах, засах, тайрах; *сэртийж гарсны нь өөлөх хэрэгтэй;* 2. ул шагаах, бусдын буруу гэмтэй талыг далимдуулах; *үг өөлөх;* 3. зэмлэх, буруутгах.

ӨӨЛӨГДӨХ өөлөхийн үйлдэгдэх хэв.

ӨӨЛҮҮЛЭХ 1. өөлөхийн үйлдүүлэх хэв; 2. өөлөгдөх.

ӨӨНТӨГ өө сэв, гэм осол; *өөнтөг эрэх; өөнтөг санах.*

ӨӨНТӨГЛӨХ өөнтөгч зан гаргах.

ӨӨНТӨГЧ ялимгүй юманд гомдолтой зантай; *өөнтөгч хүн, өөртөө бурууһай* з ү й р.

ӨӨР I 1. адилгүй, ижил биш; *энэ хоёр хоорондоо өөр; хоёр өөр зоос;* 2. ондоо, бусад; *өөр улсын харьяат; өөр хэрэг; өөр өөр ажилтай иржээ; өөр хүн; түүнээс өөр явах хүн байна уу?*

ӨӨР II хамаадуулах төлөөний үг; *өөр өөрийнхөө суудал дээрээс; өөртөө гомдох; өөрийн хүн; өөрөө мэд; өөртөө байсан мөнгийг бүгдийг орхив; өөрий нь дуудаж асуув; өөрийн муугаа хүн дээр, өөлийн хүйтнийг хавар дээр* з ү й р ; *өөрийн юм өргүй* з ү й р ; **өөр хоорондоо** (өөр зуураа): **өөр зуураа** (дотроо); **өөрийн шүүмжлэл** (өөрийн үйл явдалд шүүмжлэлтэй хандах, өөрийн ажил төрлийн алдаа дутагдлыг шүүмжлэх, өөрийн алдааг илрүүлэх зарчимч арга); **өөрийн эрхгүй** (санаанд дураар биш; *нулимс нь мэлтгэнэн өөрийн эрхгүй үйлж гарав*); **өөртөө эзэрхэх эрх** (автономи); **өөртөө тогтнох, өөртөө засах** (улсын тусгаар тогтнох).

ӨӨРГҮЙ 1. яг адил, ижил; 2. өөр юм байхгүй.

ӨӨРИЙГӨӨ биеийгээ; *өөрийгөө битгий магт, бусдыг битгий бас.* з ү й р.

ӨӨРИЙМСӨГ өөрийн юм шиг; *өөриймсөг зантай; өөриймсөг хүн итгэлтэй л байдаг даа.*

ӨӨРИЙМШИХ өөрийн юм шиг шинжтэй болох.

ӨӨРИЙМШҮҮЛЭХ өөриймшихийн үйлдүүлэх хэв.

ӨӨРИЙНСӨХ өөрийн юм шиг санах болох.

ӨӨРИЙНХ хүнийх биш, өөрийн; *өөрийнхөө санаагаар; өөрийнхөө дураар шийдвэрлэх; өөрийнх минь ирэв.*

ӨӨРӨӨ өөр II-ын хамаадуулах хэлбэр; *өөрөө хожгор байж бусдын халзанг элэглэх* з ү й р .

ӨӨРС бээр; идээ өөрс.

ӨӨРСНӨӨ өөр, өөрсдөө.

ӨӨРСӨД өөрснөө, олон; *өөрсдий нь хэлэхийг чагнах хэрэгтэй; өөрсдөөс нь лавлаж асуу.*

ӨӨРТӨХ өөр болох.

ӨӨРЦГҮЙ өөргүй, ялгалгүй; *аль нь ч өөрцгүй.*

ӨӨРЧЛӨГДӨХ өөрчлөхийн үйлдэгдэх хэв; *урьдаасаа өөрчлөгдөх; бүрэлдэхүүн нь өөрчлөгдөх.*

ӨӨРЧЛӨЛ өөрчлөх үйлийн нэр.

ӨӨРЧЛӨЛТ өөрчлөл хийх үйлийн нэр; *өөрчлөлт оруулах.*

ӨӨРЧЛӨХ өөр болгох, ондоо болгох, хувиргах; *юмны хэлбэрийг өөрчлөх; саналаа өөрчлөх; өөрчлөх юм алга; өөрчлөн засах.*

ӨӨРЧЛҮҮЛЭХ өөрчлөхийн үйлдүүлэх хэв, өөр болгуулах.

ӨӨТӨХ өө сэв бий болох.

ӨӨТҮҮЛЭХ өөтөхийн үйлдүүлэх хэв; **өөтүүлэн шийтгэх** (өө сэв шалтгаан гарган шийтгэх).

ӨӨХ (ӨӢ) амьтны биед махтай алаглан байх тосорхог зүйл; *өөхтэй мах; үхрийн өөх; уураг өөх тос нүүрс ус гурав бол хүний хоол тэжээлийн гол нь; өөхөн бөмбий, араг сагсай* о н ь с г о ; **өөх өгсөн хүнтэй өглөө босоод зургалдана** (тус хүргэсэн хүнд буруу санах); **өөх ч биш, булчирхай ч биш** (хоёрын хооронд); **өөхөн дэн** (өөхөн тосонд гол хийж асаах дэн); **өөхөн тос** (махны зүйлээс шаргааж гаргасан тос); **өөхөн чулуу** (хадан цагаан, өөхөн цагаан зэрэг зарим чулуулгуудын ерөнхий нэр); **өөх цацах** (амьтны сая өөхлөн завдах); **өөх тос** (амьтан ургамлын нэхмэлд бий усанд үл уусах тосорхог зүйл).

ӨӨХГҮЙ 1. өөх огт байхгүй; 2. маш туранхай.

ӨӨХДӨХ өөх нь ихдэх; *өөхдөөд идэж болсонгүй.*

ӨӨХЖИХ өөхтэй болох.

ӨӨХЛӨӨГҮЙ өөх сууж чадаагүй.

ӨӨХЛӨХ өөх суух, таргалж өөхтэй болох, таргалах.

ӨӨХЛҮҮЛЭХ өөхлөхийн үйлдүүлэх хэв.

ӨӨХТЭЙ өөх бүхий, өөх ихтэй; *өөхтэй хонь; өөхтэй мах.*

ӨӨЧЛӨГДӨХ өөчлөхийн үйлдэгдэх хэв.

ӨӨЧЛӨХ байн байн өөлөх, өө эрэх; *өөчлөх хэрэг байхгүй; өөчилж үзэх.*

ӨӨЧЛҮҮЛЭХ 1. өөчлөхийн үйлдүүлэх хэв; 2. өөчлөгдөх.

ӨӨШ 1. загас, шувуу барих тор; 2. загас, шувуу зэргийг агнахад идүүлж мэхлэх юм; *өөшөөр загас барих;* 3. шилжсэн идэш хахууль; *өөш өгөх.*

ӨӨШЛӨХ өөш өгөх.

ӨӨШЛҮҮЛЭХ өөшлөхийн үйлдүүлэх хэв.

ӨР I бусдад өгөх өглөг; **өр шир** хорш.; *өр ширд дарагдсан амьтан; өр нэхэх; өрөө төлөх; өргүй бол баян, өвчингүй бол жаргал* хууч *өрөнд баригдах, өтөнд идэгдэх* зүйр.

ӨР II амьтны өрцийн орчин газар; *өрий нь цоолох; өрөн дээр өвдөх;* **өр зөөлөн** (өрөвдөх сэтгэлтэй, зөөлөн сэтгэлтэй): **өр өвдөх** (өрөвдөх, хайрлах).

ӨР III 1. гэрийн шалны голд тавьдаг дөрвөлжин хүрээ, тулганы өр ч гэдэг; *шалны өр;* 2. гол төв; *өр дунд; өрий нь сайн олж тааруулахгүй бол болохгүй.*

ӨРВИЙЛГӨХ өрвийхийн үйлдүүлэх хэв, өрөвгөр болгох.

ӨРВИЙХ өрөвгөр болох; *ус чинь өрвийгөөд байна, хойш нь ил.*

ӨРВӨГНӨХ өрөвгөр юмны өрвөг өрвөг хийх.

ӨРВӨГНҮҮЛЭХ өрвөгнөхийн үйлдүүлэх хэв.

ӨРВӨЛГӨ 1. шувууны өд; **өд өрвөлгө** хорш.; *өрвөлгөн дэвсгэр; өрвөлгөн дэр;* 2. тахианы толгойн цэцэг; 3. бууран тэмээний толгой дээрх урт үс.

ӨРВӨЛЗӨХ өрөвгөр юмны өрвөс **өрвөс** хийх.

ӨРВӨЛЗҮҮЛЭХ өрвөлзөхийн үйлдүүлэх хэв.

ӨРГӨВТӨР баахан өргөн.

ӨРГӨГДӨХ өргөхийн үйлдэгдэх хэв; *дороос өргөгдөх;* **олонд өргөгдөх** (өргөмжлөгдөх); **айлд өргөгдөх** (үрчлүүлэн тэжээгдэх.

ӨРГӨДӨГ 1. өргөх юм; *өргөдөг машин;* 2. маш турж эцсэн мал.

ӨРГӨДӨХ хэтэрхий өргөн болох; *энэ мод өргөдөөд багтахгүй байна.*

ӨРГӨДҮҮЛЭХ өргөдөхийн үйлдүүлэх хэв, өргөн болгох.

ӨРГӨЖИХ 1. өргөн болох; 2. **нэмэгдэх;** өсөх; *нэгдэл, сангийн аж ахуй жилээс жилд өргөжин нэмэгдсээр байна.*

ӨРГӨЖҮҮЛЭХ өргөжихийн үйлдүүлэх хэв.

ӨРГӨЛ барьц; **өргөл барьц** хорш.; *өргөл өргөх.*

ӨРГӨЛТ 1. өргөх үйлийн нэр; 2. үгийн бусад үеэс илүү хүчтэй сонсдох үе; *Монгол хэлний өргөлттэй үе бол ямагт үгийн нэгдүгээр үед байдаг.*

ӨРГӨЛЦӨХ өргөхийн үйлдэлцэх хэв.

ӨРГӨМЖ 1. асрамж тэтгэмж; **өргөмж асрамж; өргөмж тэтгэмж** хорш.; *өргөмж муутай; өргөмж сайтай;* 2. өргөмжлөн үзэх үйлийн нэр; *өргөмжөөр дэвшсэн хүн.*

ӨРГӨМЖЛӨГ өргөмжлөх үйлийн нэр, дэмжлэг; *өргөмжлөг сайтай; өргөмжлөг муутай.*

ӨРГӨМЖЛӨГДӨХ өргөмжлөхийн үйлдэгдэх хэв.

ӨРГӨМЖЛӨЛ өргөмжлөх үйлийн нэр; *өргөмжлөл бичиг;*

ӨРГӨМЖЛӨХ хүндэтгэн өргөж тэмдэглэх; *нэр цол өргөмжлөх;* **нэхэж өргөмжлөх** (нас барсан хойно нь гавьяа зүтгэлий нь илэрхийлж тэмдэглэх).

ӨРГӨМЖЛҮҮЛЭХ 1. өргөмжлөхийн үйлдүүлэх хэв; 2. өргөмжлөгдөх.

ӨРГӨМӨЛ өргөсөн, өргөгдсөн, үрчилсэн, үрчлэгдсэн юм; *өргөмөл хүүхэд, өргөмөл ах; өргөмөл эгч.*

ӨРГӨМТГИЙ 1. өргөдөг, өргөх зантай; 2. ш и л ж с э н юмыг хэтрүүлэн магтах зантай, өргөмхий.

ӨРГӨМХИЙ өргөдөг зантай, байн байн өргөдөг, өргөмтгий.

ӨРГӨН 1. нарийн гэдгийн эсрэг утга, хөндлөн тийшээ их, хол; *өргөн гол; өргөн тал; өргөн магнайтай; өргөн энтэй бараа;* 2. ш и л ж с э н олон, үлэмж арвин; *баяр дээр хүн амьтан өргөн байв; өргөн түмэн,* 3. дэлгэр, их, олон удаа; *өргөнөөр тайлбарлан танилуулах.*

ӨРГӨӨ гэрийн хүндэтгэл; **гэр өргөө** х о р ш.; *хаан өргөөдөө залрав.*

ӨРГӨӨЛӨХ 1. гэрлэхийн хүндэтгэл; 2. хүндэтгэвэл зохих хүний гэртээ орших.

ӨРГӨӨЛҮҮЛЭХ өргөөлөхийн үйлдүүлэх хэв.

ӨРГӨРӨГ улаан замаас уртрагийн чигт градусаар хуваасан зай; **умард өргөрөг** (улаан замаас умард туйлын чиг дэх өргөрөг); **өмнөд өргөрөг** (улаан замаас өмнөд туйлын чиг дэх өргөрөг).

ӨРГӨС 1. зарим ургамалд байх зүү мэт шовх үзүүртэй зүйл; *харганын өргөс;* 2. гар хөл буюу биед шаасан мод, ургамлын өчүүхэн хэсэг; *гартаа өргөс оруулах;* 3. цоожны доторхи урт шүднүүд; *гурван өргөстэй цоож;* 4. нялх хүүхдийн анхны шүд; *урд хоёр өргөс нь цухуйжээ.*

ӨРГӨСТ өргөстэй, өргөс бүхий; **өргөст хэмх** у р г а м а л (хулуугийн намын таримал ногоо, иддэг, гонзгор ногоон үр жимстэй); **өргөст ногоо** у р г а м а л (хээр ургана, навчинд бяцхан сондуу бий); **өргөст хамхаг** у р г а м а л (мөчир олон, салаа иш улаан судалтай бөгөөд сондуу бүхий нэг зүйл ургамал, ногоон байхад малын тэжээлд хэрэглэнэ, хатсан хойноо малд хортой); **өргөст цэцэг** у р г а м а л (шар цагаан цэцэг цэцэглэж бут бутаар ургана, ишид сондуу бий); **өргөст хадаас** (нэг зүйл өргөстэй хадаас).

ӨРГӨСӨХ өргөдөх.

ӨРГӨТГӨЛ өргөтгөх үйлийн нэр; *барилгын өргөтгөл; хоёрдугаар өргөтгөл.*

ӨРГӨТГӨХ өргөн дэлгэр болгох; *зам өргөтгөх; өргөтгөсөн бүгд хурал; эмнэлгийн салбарыг өргөтгөх.*

ӨРГӨТГҮҮЛЭХ өргөтгөхийн үйлдүүлэх хэв.

ӨРГӨТӨХ улмаар өргөн болох.

ӨРГӨХ 1. юмыг өндөр болгох; **туг өргөх** (туг дээш өргөн хийсгэх); **тангараг өргөх** (тангараг өгөхийн хүндэтгэл; цэргийн тангараг өргөх); **толгойгоо өргөх** (а. толгойгоо дээш болгох; б. ш и л ж с э н сэргэх, биеэ даах, аливаа дарамт дарлалаас мултран ангижрах); **сүүлээ өргөх** (а. сүүлээ агсах; б. ш и л ж с э н сагсуурах, онгирох); **гар өргөх** (а. гарыг дээш болгох; *баруун гараа өргөж саналаа өгөв; асуух хүн байвал гараа өргөөрэй; нэг ачааны машина ирэхээр гар өргөв;* б. ш и л ж с э н бууж өгөх, дагаж орох, орж өгөх; *зогс! гараа өргө! дайсан бүслэгдэж гараа өргөж зэвсгээ хураалгав);* 2. өргөмжлөх; *сурагчдын дунг өргөж дүгнэх);* **өргөн барих айлтгах бичиг** х у у ч и р с а н (эзэд дээдэст баярын ёсоор айлтгах бичиг); **өргөн барих нугалбар** х у у ч и р с а н (доод түшмэл дээд түшмэлтэй уулзахад өөрийн овог тушаалыг бичиж гурав нугалан барих бичиг); 3. сувилах, асрамжлах; *эцэг эхээ сайхан өргөдөг хүн байгаа юм; өвчтөнг өргөж сувилах талаар эмнэлгийн газар их зүйлийг хийх хэрэгтэй.*

ӨРГҮҮ 1. юмны зах сэжүүр дээш; *өргүү ташаатай дээл;* 2. биеэ хэтэрхий дээгүүрт боддог; *өргүү хүн; өөрийгөө магтамхай.*

ӨРГҮҮДЭХ хэтэрхий өргүү болох.

ӨРГҮҮЛ өргөдөг хэрэгсэл, өргүүр; *машины өргүүл.*

ӨРГҮҮЛЭХ өргөхийн үйлдүүлэх хэв, өргөхөд хүргүүлэх.

ӨРГҮҮР өргөх багаж, өргүүл.

ӨРДӨХ I гал маш их түлэх; *зууханд гал өрдөх.*

ӨРДӨХ II өрд орох, бусдаас зээл юм авч хэрэглэх; *өрдөж аваад наргиж байна.*

ӨРДҮҮЛЭХ өрдөхийн үйлдүүлэх хэв.

ӨРЛӨГ I төрсөн биш боловч хөхөө хөхүүлсэн эх; *өрлөг эх.*

ӨРЛӨГ II цэрэг удирдах явдалд гавьяа байгуулсан их жанжны цол; *өрлөг жанжин; есөн өрлөг.*

ӨРЛӨГӨӨ өглөө.

ӨРЛӨӨГҮҮР өглөөгүүр.

ӨРЛӨХ 1. юманд өр хийх; *шал өрлөх;* 2. амьтныг алахаар өрий нь цоолох.

ӨРЛҮҮД Монголын доторхи нэгэн овог.

ӨРЛҮҮЛЭХ 1. өрлөхийн үйлдүүлэх хэв; 2. өрлөгдөх.

ӨРМӨГ нэгэн зүйл бүдүүн бараа; *өрмөг данз; өрмөг таар; өрмөг шуудай.*

ӨРНӨ баруун; *өрнө зүгээс дорно зүг хүртэл; өрнө зүгийн орнууд.*

ӨРНӨД өрнө.

ӨРНӨЛ бадрал, хөгжил; **өрнөл бадрал, өрнөл хөгжил** хорш.. .

ӨРНӨЛТ өрнөх үйлийн нэр, хөгжилт, бадрал; *өрнөлттэй; өрнөлт нь маш их.*

ӨРНӨХ бадрах, хөгжих, дэлгэрэх; *гал өрнөх; салхи өрнөх; хилэн өрнөх;* **өрнөх хөгжих** хорш..

ӨРНҮҮЛЭХ өрнөхийн үйлдүүлэх хэв; *аж ахуйг өрнүүлэн хөгжүүлэх.*

ӨРНҮҮН өрнөлттэй, дэлгэр, тэнүүн; *нийгэм жүрмын бүтээн байгуулалтын өрнүүн үед.*

ӨРӨВ I өрөвтөс.

ӨРӨВ II: **өрөв хийх** 1. өрөвсхийх, үс нь *өрөв хийж босов;* 2. ховх сорох; *өрөв хийн залгих.*

ӨРӨВГӨР сэрэвгэр, өрвийж сөрвийж ургасан, энд тэнд жаахан үзэгдэх нь; *өрөвгөр үс; өрөвгөр өвс.*

ӨРӨВДМӨӨР өр өвдмөөр, энэрэн хайрлаж үзмээр.

ӨРӨВДӨМ өрөвдмөөр байдалтай.

ӨРӨВДӨХ өр өвдөх, энэрэн хайрлах; *өрөвдөх сэтгэл; өрөвдөх сэтгэлгүй ширүүн хүн байдаг юм.*

ӨРӨВЛӨГ 1. шувууны үс; *бүргэдийн өрөвлөг;* 2. мөнхүү үсээр хийсэн юм; *өрөвлөгөн дэвсгэр; өрөвлөгөн дэр.*

ӨРӨВСӨХ өрөвдөх.

ӨРӨВТӨЛ мод зэргийг үрж засах багаж; *нарийн өрөвтөл; бүдүүн өрөвтөл.*

ӨРӨВТӨЛДӨХ өрөвтлөөр үрэх.

ӨРӨВХИЙХ загас, могой зэрэг амьтдын түргэн шалмаг хөдөлж юмыг залгих; үмхэх; *загас, ялааг өрөвхийн залгив.*

ӨРӨГ 1. харвахаар өрсөн сур буюу шагаа; *гурван өрөг харвах; эхний өрөг; дунд өрөг; адаг өрөг.* шатар даам зэрэг тоглоомын тавил; *эхний өрөг; арван тав дахь өрөг.*

ӨРӨГДӨЛ дээд газар хүмүүст өгөх бичиг; *өрөгдөл өгөх; өрөгдөл гаргах; миний өрөгдөл; өрөгдлийн хариу.*

ӨРӨГЧ юм өрдөг хүн; *үсэг өрөгч; түйпуу өрөгч.*

ӨРӨЛ ургамал долноос бяцхан иштэй, өнгө хүрэн улаан, амт хүчтэй нэг зүйл жимс, мөн өрлийн мод; *өрлийн мод.*

ӨРӨЛБӨ дархны шовхдуу хушуутай хавчих багаж: **өрөлбө бахь** хорш..

ӨРӨЛБӨДӨХ өрөлбөөр хавчих.

ӨРӨМ I хөөрүүлсэн сүүний дээгүүр бүрхэн тогтох тослог идээ; *тавагтай өрөм ааруул тавих; тогооны өрөм;* **өрөм хулгайч** амьтан (нэг зүйлийн ялаа); 2. шингэн зүйлийн хөрөх царцахад дээгүүр нь тогтох өтгөвтөр хөрс.

ӨРӨМ II дүгрэг нүх гаргах, эргүүлэн цоолох багаж; *эргүүл өрөм; зэрүүл өрөм; нумавч өрөм.*

ӨРӨМДӨГЧ 1. өрөмдөх ажил гүйцэтгэгч хүн; *уурхайн өрөмдөгч;* 2. өрөмддөг багаж.

ӨРӨМДӨХ өрмөөр нүхлэх.

ӨРӨМДҮҮЛЭХ 1. өрөмдөхийн үйлдүүлэх хэв; 2. өрөмдөгдөх.

ӨРӨМЛӨХ 1. өрөмдөх; 2. өрөмтэй болох; *тэднийх өрөмлөсөн байна.*

ӨРӨМТӨХ өрөм тогтох; *сүү өрөмтөх; ус өрөмтөх.*

ӨРӨМТҮҮЛЭХ өрөмтөхийн үйлдүүлэх хэв.

ӨРӨМЧ өрөмдөгч.

ӨРӨӨ тасалгаа; *дөрвөн өрөө байшин; галт тэрэгний өрөө; онгоцны өрөө;* **өрөө тасалгаа** хорш..

ӨРӨӨЛ I бүхэл юмыг голоор нь таллаж хуваасны нэг; хагас, тал; *өрөөл булигаар; өрөөл мах;* **өрөөлийн өрөөл** (өрөөлийн тал, талын тал, хагасын хагас); **өрөөл даавуу** (ам даавууны хагас; *өөрийн бие өөртөө зөв, өрөөл даавуу өмдөндөө зөв* зүйр).

ӨРӨӨЛ II морины нэг талын өмнө хойт хоёр хөлийг холбож торгох хэрэглэл; *өрөөлтэй морь;* **өрөөл татанхай** (өрөөсөн тал нь мэдрэл муутай).

ӨРӨӨЛДӨХ 1. юмыг өрөөл болгож хуваах, хагаслах, таллах; *мах өрөөлдөх;* 2. морины нэг талын урд хойт хоёр хөлийг торгож бэхлэх; *морио өрөөлдөж орхив;* 3. дээлийг хөндлөнгөөр нь болгож хучих; *дээлээ өрөөлдөж нөмрөн унтав.*

ӨРӨӨЛДҮҮЛЭХ өрөөлдөхийн үйлдүүлэх хэв.

ӨРӨӨЛӨХ өрөө болгох,

ӨРӨӨЛҮҮЛЭХ 1. өрөөлөхийн үйлдүүлэх хэв; 2. өрөөл болгуулах, өрөө болгуулах.

ӨРӨӨСГӨЛ 1. сондгой, хэлтгий; *гурав, тав, долоог өрөөсгөл гэнэ;* 2. хос биш; *өрөөсгөл гутал;* 3. ш и л ж с э н ижил, ханигүй.

ӨРӨӨСДӨХ өрөөсөн болох, хосгүйдэх.

ӨРӨӨСДҮҮЛЭХ өрөөсдөхийн үйлдүүлэх хэв.

ӨРӨӨСЛӨХ өрөөсөн болгох.

ӨРӨӨСЛҮҮЛЭХ өрөөслөхийн үйлдүүлэх хэв, өрөөсөн болгуулах.

ӨРӨӨСӨН хос холбоо байх юмны нэг; *өрөөсөн эвэр; өрөөсөн гутал; өрөөсөн нүдээ аних; өрөөсөн тийшээ гэлжийх.*

ӨРӨӨСТЭЙ өрж жагсаан тавьсан нь; *өрөөстэй цэцэг; ширээ дээр аяга өрөөстэй байна.*

ӨРӨХ I жигдлэн жагсаах, эгнүүлэх, зэрэгцүүлэн тавих; *шатар өрөх; шагаа өрөх; сур өрөх; үсэг өрөх; тоглоом өрөх; туйпуу өрөх.*

ӨРӨХ II барилдахаар бэлдэж зогсох; *үзүүрийн хоёр бөх дэвэн гарч ирээд шавж шавж өрөн зогсов.*

ӨРСӨЛДӨГЧ тэмцэлдэгч, урьдагч, өрсөн тэмцэгч.

ӨРСӨЛДӨӨН өрсөх тэмцэлдээн.

ӨРСӨЛЦӨХ өрсөхийн үйлдэлцэх хэв.

ӨРСӨХ тэмцэх, урьдах, түрүүлэх; *чамаас өрсч явах гэсэн чинь амжсангүй; тэр надаас өрсөөд авчихсан байна билээ.*

ӨРСҮҮЛЭХ өрсөхийн үйлдүүлэх хэв.

ӨРТӨГ 1. таваарыг үйлдвэрлэхэд гарсан хийгээд мөн таваарт биеллээ олсон хийсвэр хөдөлмөрийн зохих хэмжээ хир; **өөрийн өртөг** (аливаа эд агуурс үйлдвэрлэх, бий болгоход гарсан зардлын нийлбэр); **нэмүү өртөг** (хөлсний ажилчдаас тодорхой цагт бүтээсэн хөдөлмөрийн хөлсний төлөгдөөгүй хэсэг); 2. юмны үнэлэлтийн мөнгөн агуулга, үнэ; *худалдан авсан юмны өртөг; тээврийн өртөг; ямар өртгөөр өгөх юм бэ?*

ӨРТӨГДӨХ 1. өртөхийн үйлдэгдэх хэв; өртөх; 2. хэтэрхий үнэдэх.

ӨРТӨГЛӨХ өртөг зохиох, тогтоох.

ӨРТӨМТГИЙ өртөж явдаг; *юманд өртөмтгий хүн.*

ӨРТӨМХИЙ өртөмтгий.

ӨРТӨМШИХ хөгшрөх.

ӨРТӨӨ (Н) 1. урьдын цагт албаны хүмүүс, албаны юм зэргийг дамжуулан хүргэх морин хөсөгтэй буудлын газар, хоорондоо гучин километр орчим оршиж байсан; 2. гучин километр орчим газар; *гурван өртөө газар; өртөө улаа хэрэглэх; өртөөгөөр явах;* **өртөө хийх** (өртөөний алба залгуулах); **галт тэрэгний өртөө** (төмөр замын дагуу байгуулсан галт тэрэгний зогсоол газар).

ӨРТӨӨЛӨХ 1. өртөө мэт дараа дараагаар байх; **өртөөлөн хөөх** (амдаж ээлжлэн хөөх); 2. өртөө хэрэгсэн явах; 3. дамжлагаар дам дамжуулах; *туйпууг өртөөлөн зөөх.*

ӨРТӨӨЛҮҮЛЭХ өртөөлөхийн үйлдүүлэх хэв.

ӨРТӨӨЧИН өртөө хийгчид.

ӨРТӨХ I 1. мэдрэгдэх, харагдах, баригдах; *гарт өртөхгүй жижигхэн;* **нүдэнд өртөхгүй шахам** (бараг харагдахгүй жижиг); 2. зохисгүй юманд дайралдах, тохиолдох, нэрвэгдэх; *муу юманд өртөх; юм болгонд өртөж явах; зэрлэг суманд өртөх.*

ӨРТӨХ II өртэй болох.

ӨРТҮҮЛЭХ 1. өртөхийн үйлдүүлэх хэв; 2. өрөнд оруулах.

ӨРТЭЙ I өр ихтэй; *би таван төгрөгийн өртэй; өртэй хүн өөдлөхгүй, өттэй ямаа таргалахгүй* з ү й р.

ӨРТЭЙ II өр бий; *өртэй ширээ; өртэй олбог.*

ӨРҮҮ нөрүү.

ӨРҮҮЛ үсэг өрөхөд хэрэглэх хашлага.

ӨРҮҮЛЭХ өрөхийн үйлдүүлэх хэв.

ӨРҮҮТЭХ нөрүү болох.

ӨРХ I монгол гэрийн тооно дээгүүр бүтээж хэрэглэх исгийн зэрэг юм; **өрх бүтээх** (өрх битүүлэх); **өрх хушуулдах** (өрхний хушууг урагш болгох); **өрх татах** (өрхний хушууг хойш татах); **өрх тэгшлэх** (өрх бүтээх); **өрх дэндийлэх** (өрхийг тулж дэндийлгэх); **өрх дөрвөлжлөх** (өрх бүтээх); **өрхний гэгээвч** (өрхний дээрх цонх).

ӨРХ II айл гэр; **өрхийн данс** (айл хүмүүсийн данс); **өрхийн тэргүүлэгч** (айлын тэргүүлэгч, гэрийн эзэн); **өрх толгойлох** (айл гэрийг

тэргүүлэх); **өрх салгах, өрх тусгаарлах** (гэр хөрөнгө салгаж, өөр айл болох.

ӨРХ III 1. газрын хөрсөнд тогтсон шигдэх, хөхөх шавар бүхий нүх; *өрхөнд орох; өрхтэй газар шүү! мэдэж яваарай;* **усны өрх** (усны эргүүлэг); 2. аливаа дэлбэрэлтээс тогтсон нүх, хонхор; *галт уулын өрх.*

ӨРХЛӨХ өрх болох, өрх гарах.

ӨРЦ элэгний дүүрээ, цээжний хөндий хэвлийн хөндий хоёрыг салгасан булчин хамар.

ӨРШӨӨГДӨХ өршөөхийн үйлдэгдэх хэв.

ӨРШӨӨЛ энэрэл, энэрэнгүй тусламж, нигүүлсэнгүй тэтгэмж; **энэрэл өршөөл; хайр өршөөл** х о р ш.; *ялыг өршөөл үзүүлж хөнгөтгөх;* **өршөөл үзүүлэх** (уучлах, хэлтрүүлэх).

ӨРШӨӨЛГӨХ 1. өршөөхийн үйлдүүлэх хэв; 2. өршөөгдөх.

ӨРШӨӨЛТ өршөөл бүхий; *өршөөлт нам заса.*

ӨРШӨӨМТГИЙ өршөөнгүй, энэрэх заншилтай.

ӨРШӨӨНГҮЙ өршөөмтгий, өршөөл үзүүлдэг. энэрэнгүй.

ӨРШӨӨХ 1. энэрэн туслах, нигүүлсэн тэтгэх, нигүүлсэх, энэрэх; 2. уучлах, хэлтрүүлэх; *чамайг олон удаа өршөөсөн шүү; өршөөгөөрэй таны ажилд саад болчихов!* **бурхан өршөө!** (найтаахад өгүүлэх үг).

ӨС хонзон, өшөө; *өс санах; өс бодох; өртэй хүн зээл дээр уулзах, өстэй хүн даваан дээр уулзах* з ү й р.

ӨСВӨР өсөх үйлийн нэр; *өсвөртэй; өсвөргүй; өсвөрийн багачууд; өсвөрийн мал; өсвөр мод.*

ӨСГИЙ 1. хөлийн тавгийн хойдох бөндгөр хэсэг; *өсгийн яс; оймсний өсгий;* 2. гутлын улын хойд хэсэг; *гуталд өсгий тавиулах; өндөр өсгийтэй гутал өмсөх.*

ӨСГИЙДӨХ өсгийгөөс барих.

ӨСГИЙДҮҮЛЭХ өсгийдөхийн үйлдүүлэх хэв.

ӨСГИЙЛДӨХ 1. бөхийн мэх, өсгийгөөс барьж унагаах; 2. хууран мэхлэх.

ӨСГИЙЛДҮҮЛЭХ өсгийлдэхийн үйлдүүлэх хэв.

ӨСГӨВӨР өсгөх үйлийн нэр; *өсгөврийн мал.*

ӨСГӨГЧ 1. өсгөдөг, бойжуулагч, хүмүүжүүлэгч; *хүүхэд өсгөгч; мал өсгөгч;* 2. томруулагч; *өсгөгч шил.*

ӨСГӨДӨГ 1. бойжуулагч, хүмүүжүүлэгч; 2. өсгөгч; *өсгөдөг шил.*

ӨСГӨЛӨН бадриун, биерхэг, торниун.

ӨСГӨН өтгөн.

ӨСГӨРӨЛТ өтгөрөлт.

ӨСГӨРӨХ өтгөрөх.

ӨСГӨРҮҮЛЭХ өсгөрөхийн үйлдүүлэх хэв; өтгөрүүлэх.

ӨСГӨХ 1. өсөхийн үйлдүүлэх хэв, өсөхөд хүргүүлэх; 2. бойжуулах, торниулах; *мал өсгөх; хүүхэд өсгөх;* 3. олшруулах, нэмэгдүүлэх; *үхэр сүргийн тоог өсгөх; малын тоог өсгөх; сургуулийн тоог хэдэн хувиар өсгөх вэ?*

ӨСГҮҮЛЭХ өсгөхийн үйлдүүлэх хэв, өсгөхөд хүргүүлэх.

ӨСӨГ I айраг цэгээ.

ӨСӨГ II өтөг.

ӨСӨГЛӨХ 1. айраглах, өсөгтэй болох; 2. өтгөлөх, өтгөн болгох.

ӨСӨЛТ торнилт, томролт, бойжилт; *хөгжилт; үйлдвэрлэх хүчний өсөлт.*

ӨСӨРХӨХ өс санах, өшөөрхөх.

ӨСӨХ торних, том болох, их болох, арвижих, олон болох; *хүүхэд өсөх; мод өсөх; будаа өсөх; мал өсөх; өсөхөд шүд цагаан, өтлөхөд үс цагаан, үхэхэд яс цагаан* (аман зохиолоос).

ӨСТ өс бүхий, өшөө бүхий; *өст дайсан.*

ӨСТӨН өстэй болсон этгээд; *өстөн дайсан; өөрийн нөхөд баярлахад өстөн дайсан хорсох* з ү й р.

ӨСТЭЙ өс бүхий, өшөө бүхий; *өстэй этгээд; өстэй хүнээс зайл! өстэй бүү бол!*

ӨТ (ӨН) ясгүй зөөлөн биетэй уртавтар шавьжуудын ерөнхий нэр; *өрөнд баригдаж, өтөнд идэгдэх* з ү й р.

ӨТГӨДӨХ хэтэрхий өтгөн болох.

ӨТГӨДҮҮЛЭХ өтгөдөхийн үйлдүүлэх хэв.

ӨТГӨН 1. шингэний эсрэг утга, агшуун, нуршин; *өтгөн цай; өтгөн бэх;* 2. игц, чигжүү; *өтгөн үстэй; өтгөн ургасан ой;* 3. дууны бүдүүн, анир ихтэй; *өтгөн дуутай;* 4. **хүний баас;** *өтгөн хатах; өтгөн мөр үзэх.*

ӨТГӨР этгэр, үрчгэр хорчгор.

ӨТГӨРӨЛТ өтгөрөх үйлийн нэр, явц.

ӨТГӨРӨХ 1. шингэн юмны агшуун нуршин болох; *шөл өтгөрч орхижээ;* 2. сийрэг, цөөн юмны олон, игц, чигжүү болох; 3. шилжсэн малын сүү шим татрах; *үнээ өтгөрч байна;* 4. дууны бүдүүн, анир ихтэй болох; *дуу өтгөрөх.*

ӨТГӨРҮҮЛ юмыг өтгөн болгох багаж.

ӨТГӨРҮҮЛЭХ өтгөрөхийн үйлдүүлэх хэв, өтгөрөхөд хүргүүлэх.

ӨТГӨС хөгшид настан; *өвгөд өтгөс.*

ӨТИЙХ өтгөр болох.

ӨТЛӨХ хөгшрөх, насжих.

ӨТЛҮҮЛЭХ өтлөхийн үйлдүүлэх хэв.

ӨТӨВХИЙХ хумайж явцуурах; *гутал өтөвхийх; арьс шир өтөвхийх.*

ӨТӨГ I малын баас, аргалын хэмхдэг; өтөг бууц хорш.; **өтөг хорхой** амьтан чийгтэй газар бойжих нэг зүйл шавьж, толгой цагаан, бие улаан).

ӨТӨГ II айраг зэрэг шингэн юмны тунасан өтгөн, нитгэл; *айрагны өтөг; нефтийн өтөг.*

ӨТӨГ III баавгай.

ӨТӨГЖИХ өтөг ихтэй болох.

ӨТӨГЖҮҮЛЭХ өтөгжихийн үйлдүүлэх хэв.

ӨТӨГШИХ өтөгтэй болох.

ӨТӨГШҮҮЛЭХ өтөгшихийн үйлдүүлэх хэв.

ӨТӨЛ 1. энгийн, жирийн, доод; *өтөл хүн; өтөл ард; өтөл боол;* 2. хөгшин; *өтөл нас.*

ӨТӨХ өттэй болох; *малын шарх өтөх; өрөм өтөх.*

ӨТРӨХ атирах, үрчийх, атриатах.

ӨТҮҮЛЭХ өтөхийн үйлдүүлэх хэв, өтөхөд хүргүүлэх.

ӨТЧЛӨХ өтийг арилгах.

ӨТЧЛҮҮЛЭХ өтчлөхийн үйлдүүлэх хэв.

ӨТЧЛҮҮР өт ухаж арилгах хэрэглэл.

ӨХ өгөх.

ӨХИЙ бөхийн мэх, барилдахдаа эсэргүүцлийн хөлийг нэг хөлөөр дотогш гохдох мэх.

ӨХИЙДӨХ барилдахад эсэргүүцлийн хөлийг нэг хөлөөр дотогш гохдон татаж гэдрэг тийш түрэн унагаах.

ӨХИЙЛДӨХ өхийдөх, өхий хийх.

ӨХИЙ өгий.

ӨЦГӨР оцгор, босоо болоод урагш бөхгөр.

ӨЦИЙЛГӨХ өцгөр болгох.

ӨЦИЙХ өцгөр болох.

ӨЦӨГ өчүг.

ӨЦӨГДӨР өнөөдрийн урьдах өдөр.

ӨЦӨГНӨХ өцгөр юмны өцөг өцөг хөдлөх.

ӨЦӨГНҮҮЛЭХ өцөгнөхийн үйлдүүлэх хэв.

ӨЦӨД үйлдэх бүтээхэд хялбар хөнгөн юм шиг болоөч тийм биш төвөгтэй.

ӨЦӨЛЗӨХ өцгөр юмны өцөс өцөс хөдлөх.

ӨЦӨСХИЙХ давхийн өцийх, гэнэт өцийх.

ӨЦҮҮТЭХ юмны улмаар өчүүхэн болох.

ӨЦҮҮХЭН 1. жижигхэн, бага, бяцхан, өчүүхэн; *өцүүхэн биетэй; өцүүхэн дуугаар;* ☆ **өцүүхэн дүүрэн** (сарны зурхайн ёсны хорин дөрвөн улирлын хувиарын нэг, нарны зурхайн тавдугаар сарын хорин нэгнээс зургадугаар сарын таван хүртлэх үе); **өцүүхэн халуун** (сарны зурхайн ёсны хорин дөрвөн улирлын хувиарын нэг, нарны зурхайн долдугаар сарын тавнаас хорин нэгэн хүртлэх үе); **өцүүхэн хүйтэн** (сарны зурхайн хорин дөрвөн улирлын хувиарын нэг, нарны зурхайн нэгдүгээр сарын тавнаас хорин нэгэн хүртлэх үе); **өцүүхэн цас** (сарны зурхайн хорин дөрвөн улирлын хувиарын нэг, нарны зурхайн ёсны арван нэгдүгээр сарын хорин нэгнээс арван хоёрдугаар сарын таван хүртлэх үе); 2. хоромхон зуур; түр зуур; *өцүүхэн сууж байгаад одов; өцүүхэн унтах;* 3. мөхс, доод; *өцүүхэн хүн хянаж үзвэл...*

ӨЦҮҮДЭХ багадах, жижигдэх.

ӨЦҮҮХМЭД отгон, хамгийн бага.

ӨЧ: өч авах зоо авах.

ӨЧИГ 1. асуугдаж байгаа хүний хариу үг; ам өчгөө **өгөх** (заавал чингэнэ гэж ам өгөх, амлах); 2. байцаагдаж бухий этгээдийн мэдүүлэг, хэлэх үг; **өчиг мэдүүлэг** х о р ш.; *өчиг авах.*

ӨЧИГЛӨЛ өчиг, өчлөг үг.

ӨЧИЛ өчиж хэлэх үг; *өчил өчин, сацал сацав.*

ӨЧИХ 1. учир мэдүүлэх, айлтгах, хэлэх; хэлэх **өчих** х о р ш.; *ийн өчрүүн... өчих үг минь...* 2. байцаагдан хэрэг мэдүүлэх; *үнэнийгээ өчиж байна.*

ӨЛӨГ өчиг.

ӨЧНӨӨН өдий чинээн, энэ мэт, ийм тоотой, хэмжээтэй: **өчнөөн төчнөөн** х о р ш.; *өчнөөн их; өчнөөн удаан явахад... өчнөөнийг олов.*

ӨЧҮҮДЭХ хэтэрхий өчүүхэн болох, багадах.

ӨЧҮҮЛЭХ өчихийн үйлдүүлэх хэв.

ӨЧҮҮТГЭХ багатгах.

ӨЧҮҮТЭХ улмаар өчүүхэн болох.

ӨЧҮҮХЭН өцүүхэн; **өчүүхэн шихэн** (маш цөөн).

ӨШ өшөө, өс; *өш санах.*

ӨШИГЛӨВӨР тийрэх пүрш.

ӨШИГЛӨХ 1. хөлөөр тийрэх; *морь өшиглөх; бөмбөг өшиглөх;* 2. тулгуурлах.

ӨШИГЛҮҮЛЭХ өшиглөхийн үйлдүүлэх хэв.

ӨШИГЛҮҮР өшиглүүлэн тулсан юм.

ӨШИГЧИХ байн байн өшиглөх, олны өшиглөх.

ӨШИГЧҮҮЛЭХ өшигчихийн үйлдүүлэх хэв.

ӨШИХ хорсол хадгалах, занах өшөөтэй болох; *дотроо өшин занаж байлаа.*

ӨШӨӨ өвөрлөсөн занал, хадгалсан хорсол, өс; *өшөө санаж явах;* **өшөө хонзон** х о р ш.; **өшөө өвөрлөх** (өших); **өшөө бололцох** (харилцан өших); **өшөө авах** (өшсөн санаагаа биелүүлэх).

ӨШӨӨЛӨХ өшөө өвөрлөх, өшөөгөө авах, өшөөгөөр хорлох.

ӨШӨӨЛҮҮЛЭХ 1. өшөөлөхийн үйлдүүлэх хэв; 2. өшөөлөгдөх.

ӨШӨӨРХӨХ өшөө санаж явах, занаж явах; *өшөөрхөн хорложээ.*

ӨШӨӨРХҮҮЛЭХ өшөөрхөхийн үйлдүүлэх хэв.

ӨШӨӨТӨН өшөө бүхий, өс бүхий; *өшөөтөн дайсанд өврөө бүү үзүүл, атаатан дайсанд араа бүү үзүүл* х у у ч.

ӨШӨӨТЭЙ заналтай, хорсолтой, өшиж, занаж явдаг, өстэй; *өшөөтэй хүн.*

ӨШРӨГДӨХ өшөөтэй болох, өшөө санаж явах, хорсч явах, өстэй болох.

ӨШРҮҮЛЭХ 1. өшрөхийн үйлдүүлэх хэв; 2. **өшрөгдөх.**

П

П п үсэг, п авиа

ПАА жигшиж цээрлэсэн үгийн өмнө хэрэглэх аялга; *паа, та чинь ямар муухай амьтан бэ? паа, би бол яасан ч чингэхгүй.*

ПААДАЙЛГАХ паадайхын үйлдүүлэх хэв.

ПААДАЙХ паадгар болох.

ПААДАЛЗАХ паадгар паадас паадас хөдлөх.

ПААДГАНАХ паадгар юмны паадга паадга хөдлөх.

ПААДГАР богино, тагдгар.

ПААЛАН 1. төмөрлөг эд хэрэглэлд гүйлгэн түрхэх тунгалаг биш шил будаг; *паалан гүйлгэсэн сав; паалантай хувин;* 2. шүдний гадуурхийг бүрхэх бодис; *шүдний паалан.*

ПААЛАНДАХ юманд паалан гүйлгэх, түрхэх; *энгэрийн тэмдгийг пааландах.*

ПААЛАНДУУЛАХ пааландахын үйлдүүлэх хэв.

ПААЛАНТАЙ паалан түрхсэн нь; *паалантэй хувин; паалантай тоосго.*

ПААЛАНШИХ паалангийн шинжтэй болох.

ПААХ жигшиж цээрлэсэн үгийн өмнө хэрэглэх аялга; *паах, чи яаж байгаа нь энэ вэ?*

ПАВИЛЬОН үзэсгэлэнгийн барилга; *наадмын павильон; хөдөө аж ахуйн павильон.*

ПАГ яг, шал дорой; *сурлагаар паг;* **паг амьтан** (юу ч мэдэхгүй амьтан); **паг болох** (а. огт дуугарахгүй болох; б. мухардах).

ПАГДАЙЛГАХ пагдайхын үйлдүүлэх хэв.

ПАГДАЙХ пагдгар болох.

ПАГДАЛЗАХ пагдгар юмны пагдас пагдас хөдлөх.

ПАГДГАНАХ пагдгар юмны пагдга пагдга хөдлөх.

ПАГДГАР тагдгар богино, паадгар

ПАГДГАРДАХ хэтэрхий пагдгар болох.

ПАГС I будаг, цавуу зэргийг юманд түрхэхэд хэрэглэх хялгасаар хийх хэрэгсэл; *будагны пагс; пагсаар будах.*

ПАГС II: паг **жимс** у р г а м а л хундганы мэт том, өнгө сэмжний адил, галд ээж идвэл амт нь гахайн мах мэт байдаг.

ПАГСДАХ пагсаар түрхэх.

ПАД I: **пад пад хийх** хатуувтар юмыг цохих, тоншиход гарах чимээ; *гуяа пад пад хийтэл алгадав.*

ПАД II хар, харанхуйн үлэмжийг үзүүлэх үг; *пад хар; пад харанхуй.*

ПАДААН бараа таваар мэтийг илгээхэд түүний тоо ширхэг, үнэ зэргийг бичсэн бичиг; *падаанаар шилжүүлэх.*

ПАДАН пад II; *падан хар; падан харанхуй.*

ПАДХИЙХ пад пад хийх.

ПАЙ I даалуу.

ПАЙ II: **пай пүй болох** юмнаас сэжиглэх жигших аялга.

ПАЙ III бай.

ПАЙЗ 1. шошго, албан ёсны тусгай үг бичигтэй төмөрлөг буюу модон ялтас; *алтан ордны мөнгөн пайз; пайзны бичиг;* **хадлангийн пайз хатгасан газар** (айл буулгахгүй, мал билчээхгүйн тул босгосон тэмдэг); 2. данслах, буртгэх, дэс дугаарлах зэрэгт хадах, олгох дугаар бүхий ялтас; *дугуйны пайз; хурдан морины пайз.*

ПАЙЗЛАГДАХ пайзлахын үйлдэгдэх хэв.

ПАЙЗЛАХ пайзтай болгох,

ПАЙЗЛУУЛАХ 1. пайзлахын үйлдүүлэх хэв; 2. пайзлагдах.

ПАЛ: пал хийх 1. усанд юм унахад гарах чимээ; 2. сочиж зүрх догдлох; *дотор зүрх пал хийгээд л явчихлаа шүү;* **пал пал хийх** (дэмий олон үг ярих).

ПАЛАН салан; **салан палан** х о р ш..

ПАЛАНЦАГ салан, заваан; *гаднаа гялайцаг; дотноо паланцаг.*

ПАЛЕОНТОЛОГИ эртний амьтны судлал.

ПАЛЕОНТОЛОГИЧ эртний амьтан судлалч.

ПАЛХАЙЛГАХ палхайхын үйлдүүлэх хэв.

ПАЛХАЙХ палхгар болох.

ПАЛХАЛЗАХ палхгар юмны палхас палхас хөдлөх.

ПАЛХАЛЗУУЛАХ палхалзахын үйлдүүлэх хэв.

ПАЛХГАНАХ палхгар юмны палхга палхга хөдлөх.

ПАЛХГАНУУЛАХ палхганахын үйлдүүлэх хэв.

ПАЛХГАР богино тагдгар бөгөөд будуун тарган; *палхгар тарган шар.*

ПАЛХИЙХ 1. шингэн юм руу унах зэрэгт гарах чимээ; *усан дотор палхийтэл унав; аягатай цайгаа палхийтэл алдаж орхив;* 2. ш и л ж. с э н сочих, айх зэрэгт догор гэнэт аягүй болох; *дотор палхийх; зүрх палхийв.*

ПАЛЬТО ихэнхдээ өвдөгнөөс доогуур татсан хормойтой нэг зүйл гадуур хувцас; *хавар намрын пальто; өвлийн пальто.*

ПАМБАГАР бамбагар, зузаан; *памбагар уруултай; памбагар дэвсгэр.*

ПАМБАГАНАХ памбагар юмны памбага памбага хөдлөх.

ПАМБАГАРДАХ хэтэрхий памбагар болох.

ПАМБАГАРДУУЛАХ памбагардахын үйлдүүлэх хэв.

ПАМБАЙЛГАХ памбайхын үйлдүүлэх хэв, памбагар болгох.

ПАМБАЙХ бамбайх, памбагар болох.

ПАМБАЛЗАХ памбагар юмны памбас памбас хөдлөх.

ПАН: пан пан хийх хөндийвтөр юмны чанга дуугарах чимээ; *буу пан пан дуугарч байв; бууны дуу пан хийн, пүн хийн, болд сэлэм жад хан хийн* (шүлэг).

ПАНДАЙЛГАХ пандайхын үйлдүүлэх хэв, пандгар болгох.

ПАНДАЙХ зузаан, хөвсгөр болох, бандайх.

ПАНДАЛЗАХ пандгар юмны пандас пандас хөдлөх.

ПАНДГАНАХ пандгар юмны пандга пандга хөдлөх.

ПАНДГАР бандгар, тэнтгэр.

ПАНЗ наймаа; **панз наймаа** х о р ш.; **панз үсэргэх** (дамлан наймаа хийх).

ПАНЗЛАХ панз хийх, наймаа хийх.

ПАНЗЧИН панз хийдэг хүн; *дамын панзчин.*

ПАНС (АҢ) нэгэн зүйл нимгэн торгомсог бараяны нэр; *цэнхэр пансан алчуурыг цэцэг навчаар гоёв* (дуу).

ПАПИРОС цаасанд ороомол тамхи.

ПАР: пар пар хийх, пар пар дуугарах хатуу сарчгар юмыг цохих, тоншиход гарах чимээ; *бага алаг бөмбөрийг, пар пар дугарахын хамтаар, багачууд хүүхэд бүгдийн маань, баяр зөриг хөгжинө дөө, бэлхэн ээ* (пионерийн дуунаас).

ПАРАЛЛЕЛ зэргэд; **параллел шугам** (зэргэд шугам).

ПАРАШЮТ шүхэр; *парашютаар буух; парашютын спорт.*

ПАРАШЮТАТ парашют бүхий; *парашютат цэрэг.*

ПАРЛАМЕНТ зарим хөрөнгөтөн орны төлөөлөгчдийн хууль тогтоох дээд хурал; *парламентын сонгууль.*

ПАРТ сургуулийн сурагчдын суух сандал-тайгаа үргэлж ширээ.

ПАРТИЗАН ардын журамт цэрэг, гадаадын халдан довтлох дайсантай тулалдах биеэ даасан анги бүлэгтэй бөгөөд дайсны ард амьд хүч, техникийг устган, зам харилцааг таслах зэрэг ажлыг хийх ардын зэвсэгт тэмцэлд сайн дураар оролцогч; *партизаны дуу.*

ПАС пад.

ПАСПОРТ 1. үзүүлэгч хүний хаана ажиллах, оршин суух зэргийг тодорхойлсон албан ёсны баримт; *иргэний паспорт; паспортын хэлтэс;* 2. машин болон аж ахуйн хэрэгслийн зүйлд дагалдуулсан баримт бичиг; *машины паспорт.*

ПАССИВ үйлдвэрийн газрын бүх өр ширийн бөөгнөрөл.

ПАТРИОТИЗМ эх оронч үзэл.

ПАХ утаанд утагдан бачимдахад гаргах аялга; *пах, ямар сүрхий утаа вэ!*

ПЕЛЕС тогоруу шувууны өөр нэр.

ПЕНДУАН янз яндуантай адил нэгэн зүйл торго.

ПЕРПИНДИКУЛЯР нэг шугам дээр тэгш өнцөг үүсгэх нөгөө шулуун шугам; эгц шугам, өгцлүүр.

ПИВ шар айраг, арвайгаар нэрэх, бага шиг архины охьтой унд; *аяга пив; пивний мухлаг.*

ПИГ маш; *пиг дүүрэн хүнтэй; пиг дүүрэн авдар.*

ПИД: пид хийх, пид пид хийх хатуу юмыг дэлдэхэд гарах чимээ.

ПИЖИГНЭХ нүргээн доргионтой чимээ гарах; **пажигнах пижигнэх** х о р ш.: *агны туурай пижигнэн...*

ПИЙПАА чавхдаст хөгжмийн зэвсэг.

ПИЙШИН тоосго буюу ширмэн зуух; *дөрвөлжин пийшин; босоо пийшин хоёр пийшинтэй орон сууц;* **уурын пийшин** (усны халуун уур гүйж халаах хэрэгсэл).

ПИН I 1. амбаар, юм агуулах хадгалах бүдүүн маягийн жижиг байшин; **пин саравч** х о р ш.; 2. гэр байшингийн үүдний урд байх бяцхан өрөө; *үүдний пин.*

ПИН II: **пин хийх** цууриатай юмны унах, цохих зэрэгт гарах чимээ; *дүнз пин хийтэл унаж байв.*

ПИН III х у у ч и р с а н хааны тавдугаар хатан.

ПИНС тэгнүүр хэмжүүр.

ПИНСЛЭХ пинсээр хэмжих, тэгнүүрдэх.

ПИНТҮҮ толгойн үсийг тэгшлэн тайрсан нэг зүйл маяг; **пинтүү тавих** (үсээ пинтүү болгон засах).

ПИОНЕР хүүхдийн хувьсгалт байгууллагын гишүүн; *пионер багачууд; пионерийн цуглаан; пионерийн дуу; пионерийн лагерь.*

ПИР: пир пир хийх 1. нүргээнтэй юмны нурах, унах зэрэгт гарах чимээ; *мөс цөмөрч пир пир чимээ гарч байв;* 2. хазах зажлах, дарах, гишгэх зэрэгт гарах чимээ; *цас пир пир хий-*

тэл цөмрөх; түүхий ногоо хазахад пир пир хийгээд аягүй шүү.

ПИРЖИГНЭХ пир пир хийх чимээ гарах.

ПИРЭН: пирэн паран 1. юм нурахад гарах чимээ; 2. олон юмны чимээ зэрэгцэн гарах.

ПИС: пис хийх дотроо хөндий, хийтэй юмны хагарах, дэлбэрэх зэрэгт гарах чимээ; *пис хийтэл хагарах.*

ПИТЛЭЭ амьтан далайд төрдөг, алтан хацарттай адил бөгөөд хайрс их нэгэн зүйл загас.

ПИУ билет, тэмдэгт; *худалдааны пиу.*

ПИУГҮЙ билет тэмдэгтгүй.

ПЛАКАТ зурагт хуудас.

ПОВААРЬ ургамал өмнө зүгийн ургамал, мөн ургамлын хар үр нь гашуун, халуун амттай ногооны зүйл.

ПОДАНЬ ургамал янз ногоон чавганы адил, үнэр амт сайн, буцалгасан усанд тавивал хальс нь өөрөө ховхрон унана, далайн арлын хүмүүс исгээд удаан хадгалж хэрэглэдэг.

ПОЖУР ургамал янз лесийн адил, амт амтайхан, цөмийг ховхлон иддэг нэгэн зүйл жимс.

ПОЛ: пол пол хийх шингэн юм шалих цохиход гарах чимээ.

ПОЛОСАА бөмбөлөг сэвгийн адил болоод том нь.

ПОМБОГОНОХ помбогор юмны помбого помбого хөдлөх.

ПОМБОГОР бомбогор, бондгор.

ПОМБОЙЛГОХ помбойхын үйлдүүлэх хэв, помбогор болгох.

ПОМБОЙХ помбогор болох.

ПОО буу.

ПООДОХ буудах.

ПООЛУУ I сийрс дэрсээр сүлжиж хийсэн тогоо түмпэн мэт хэлбэртэй сав.

ПООЛУУ II пуулуу.

ПООЧ бууч.

ПОР: пор пор хийх шингэн юмны буцлахад гарах чимээ; *тогоотой шөл пор пор хийн буцалсаар байв.*

ПОРЧИГНОХ буцалж байгаа шингэн юмнаас пор пор дуу гарах.

ПӨМБИЙЛГӨХ пөмбийхийн үйлдүүлэх хэв, пөмбөгөр болгох.

ПӨМБИЙХ пөмбөгөр болох, бөмбийх.

ПӨМБӨГНӨХ пөмбөгөр юмны пөмбөг пөмбөг хөдлөх.

ПӨМБӨГӨР бөмбөгөр, бумбагар.

ПӨМБӨГӨРДӨХ хэтэрхий пөмбөгөр болох.

ПӨМБӨГӨРДҮҮЛЭХ пөмбөгөрдөхийн үйлдүүлэх хэв.

ПӨХ муухай үнэр юмнаас жигших, зэвүүцэхэд гарах аялга; *пөх, яасан өмхий юм бэ! пөх, даан ч ийм юм хийх гээж дээ.*

ПРАКТИК 1. үйлдвэрлэлийн явцад байгаль, нийгэмлэгийн харилцааг өөрчлөх үйл ажиллагаа; *онол практикийн холбоо;* 2. аливаа юмыг амьдралд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, дадлага; *практиктай хүн;* **практик хийх** (дадлага хийх).

ПРОГРАММ 1. мөрийн хөтөлбөр; *намын программ;* 2. хөтөлбөр; *хичээлийн программ; концертын программ.*

ПРОКУРОР хууль хамгаалагч, хууль дүрмийг ёсчлон биелүүлж бий эсэхийг хянах улсын хяналтыг хэрэгжүүлэн биелүүлэх албан тушаалтан; *улсын прокурор; аймгийн прокурор; прокурорын газар.*

ПРОЛЕТАРИ капиталист нийгэмлэгт хөрөнгөтөн нарт мөлжигдөн дарлагдаж байдаг, үйлдвэрлэлийн хэрэгсэлгүй хөлсний ажилчин: *орон бүхний пролетари нар нэгдэгтүн! пролетарийн хувьсгал; пролетарийн интернационализм.*

ПРОЛЕТАРИЖИХ пролетаритай болох.

ПРОЛЕТАРИШИХ пролетари шинжтэй болох.

ПРОПОРЦИ хэмнэг; *пропорци чанар.*

ПРОПУСК аливаа юманд нэвтрэн орох, мөн аливаа юмыг нэвтрэн гарах эрхийн үнэмлэх; *дэлгүүрт орох пропуск; пропуск авах.*

ПРОТОКОЛ 1. хурлын товч тогтоол, зөвлөлгөө ярианы тэмдэглэл; *хурлын протокол;* 2. олон улсын хэлэлцээний нэгэн хэлбэр; *харилцан туслалцах протоколд гарын үсэг зурав.*

ПРОТОПЛАЗМ ургамал, амьтны бие махбодын эсийн үндсэн эд, анх сийвэн.

ПРОФЕССОР 1. эрдэмтэн, дээд сургуулийн багш нарын тэргүүн цол; 2. мөнхүү цолтой хүн.

ПРОЦЕНТ хувь.

ПУЙ: пуй пай юмнаас сэжиглэх жигших аялга.

ПУЛ: пул хийх шингэн юманд юм унахад гарах чимээ; *чулуу усанд пул хийтэл унав.*

ПУЛЕМЁТ хүчирхэг автомат хурдан буу; *пулемётоор шүрших; дөрвөлжин сумийнхээ үүдэнд, дөрвөн пулемёт зоосон юм* (Шивээ Хиагт дуу).

ПУЛНАА улнаа.

ПУН хүндийн хэмжээ, лангийн зууны нэг.

ПУР: пур хийх, пур пур хийх бургилах, буцлах мэтэд гарах чимээ; *утаа пур пур хийх.*

ПУРХИЙХ пур хийх.

ПУРЧИГНАХ утаа тоос мэтийн юм бургих; *замын тоос пурчигнана.*

ПУУЖИН 1. буудсаны дараа агаарт тод өнгө гарган нисэх тусгай сум; *пуужингаар дохио өгөх*; 2. цаасан буу; **пуужин тавих** (пуужинг асааж дуугаргах).

ПУУЖИНТ пуужин бүхий; **пуужин зэвсэг** (залууртай ба залуургүй нисэх сум).

ПУУЛУУ 1. хушиг харвах төмөр буюу өөр зүйлээр үйлдсэн бөмбөг; 2. морин дээрээс цохиж наадах бөмбөг наадам; *пуулуу цохих.*

ПҮВИН ургамал цэцэгтэйгээ, цөмөөшнө тахиа загасны холимогт чанаж идэхэд маш тохиромжтой, зэрлэг ургадаг нэгэн зүйл жимс.

ПҮД: пүд хийх юм тасрах, мулт, огло үсрэх зэрэгт гарах чимээ; *пүд хийн тас үсрэв.*

ПҮЙПАЙ их л жигшихэд гаргах аялга; *пүйпай, бүү үзэгдэ!*

ПҮЛ: пүл пүл хийх, пүл пол хийх пал, цөл.

ПҮЛХИЙХ палхийх.

ПҮН I 1. нэг ямхыг арав хуваасны нэг хувь; 2. арван лий.

ПҮН II: **пүн хийх, пүн пүн хийх** панхийх.

ПҮНЗ 1. юм агуулах бяцхан нөмөр орон; 2. тугал хаших дулаан хороо; *тугалын пүнз.*

ПҮНЛҮҮ хуучирсан тусгай журмаар олгох тогтмол цалин.

ПҮНХГЭР бөмбөгөр, тал бөөрөнхий хэлбэртэй; *пүнхгэр оройтой байшин.*

ПҮНХИЙХ I пүнхгэр болох, түнхийх.

ПҮНХИЙХ II дув дулаан, салхигүй болох; *гэрийн хаяаг манаж орхимогц пүнхийж орхив.*

ПҮНХУАН гарди гэдэг шувуу.

ПҮРД: пүрд хийх гал нурам зэрэг халуун юм дээр шингэх юм асгахад гарах.

ПҮРДХИЙХ пүрд гэж дуугарах.

ПҮРШ уян хатан ган ороомог буюу уян хатан ган сүлжмэл; *орны пүрш; пүрш нь сулрах.*

ПҮРШТЭЙ пүрш бүхий; *пүршtэй сандал.*

ПҮРЭВ I долоо хоногийн дөрөвдүгээр өдөр

ПҮРЭВ II нарны аймгийн нэг ертөнц.

ПҮҮ I хүнд хөнгөний хэмжээ, 16,3 килограмм.

ПҮҮ II: **пүү халуун** хамгийн их халуун; *зуны пүү халуун.*

ПҮҮД пүү I.

ПҮҮЗ I худалдааны гэр.

ПҮҮЗ II 1. хуучирсан феодал ноёдын хүрэмний ар өвөр тал мөн мөрөн дээр хадах дүгрэг буюу дөрвөлжин хэлбэртэй ямбаны тэмдэг; 2. дугараг хэлбэртэй нэгэн зүйл хээ угалз.

ПҮҮЛЭХ пүүгээр хэмжих.

ПҮҮС пүүз, **пүүсэн хээ** (дүгрэг хээ).

ПҮҮСГЭР түүсгэр; *пүүсгэр зузаан дээл.*

ПҮҮСИЙХ түүсийх, пүүсгэр болох.

ПҮҮСҮҮ хээгүй торго.

ПФҮҮ ядрах, халууцахад хэлэх аялга; *пфүү, ямар халуун юм бэ?*

ПЭЙ хуучирсан хааны дөрөвдүгээр хаган.

ПЭЛИЙХ пялайх; *дотор пэлийх.*

ПЭМБИЙХ памбайх.

ПЭМБЭГНЭХ пэмбэгэр юмны пэмбэг пэмбэг хөдлөх.

ПЭМБЭГЭР памбагар.

ПЭМБЭЛЗЭХ пэмбэгэр юмны пэмбэс пэмбэс хөдлөх.

ПЭНДГЭР пандгар.

ПЭНДИЙХ пандайх.

ПЭНДЭГНЭХ пэндгэр юмны пэндэг пэндэг хөдлөх.

ПЭНДЭЛЗЭХ пэндгэр юмны пэндэс пэндэс хөдлөх.

ПЭНС пэнз, түмпэн.

ПЭНСЭЛДЭЙ жижигхэн пэнс.

ПЭЭ жигших, гайхах, гэмшихэд гаргах аялга; *пээ, ямар муухай юм бэ! пээ, тоогүй! пээ, бүү үзэгд!*

ПЯЛ бяцхан ялтгар таваг.

ПЯЛАЙХ 1. нэлийх, шингэн зүйлийн цэлийж асгарсан байдал; *пялайтал асгах;* 2. ш и л ж с э н бялуурах; *дотор пялайх.*

ПЯНЗ эгшигт хайрцгийн аялгуу, дуу бичээстэй зэгээрэнцэр дүгрэг.

ПЯС: пяс хийх тасхийх, чад хийх; *пяс хийн хагарах.*

Р

Р р үсэг, р авиа.

РАВЖИМ тооны нэр, арван цагчиг.

РАДИАТОР моторын ус хөргөдөг багаж; *машины радиатор.*

РАДИЙ химийн махбод, гэрэл дулааны эрчим хүч гаргах металл.

РАДИКАЛ I язгуурын тэмдэг.

РАДИКАЛ II зүүний буржуйлэг намын талынхан, түүний гишүүн.

РАДИКАЛИЗМ радикалуудын улс төрийн үзэл, тэдний хөдөлгөөн.

РАДИО 1. тусгай станцаас явуулах цахилгаан соронзны долгионоор дуу ба тэмдгийг утасгүй илгээх, хүлээн авах арга; *радиог Оросын эрдэмтэн Попов нээн олжээ;* 2. ийм аргаар дууг хүлээн авах хэрэгсэл; *радио тавих;* 3. ийм аргаар дамжуулж байгаа дуу аялгуу; *радио чагнах;* **зураг радио** (цахилгаан соронзон долгионы тусламжаар алсаас юмны байдал дүрсийг гаргах дэлгэцтэй радио); **радио идэвх** (цацраг идэвх); **радио идэвхт** (цацраг идэвхт); **радио хүлээн авагч** (радиогоор дамжуулсан **авиа чимээг** хүлээн авах хэрэгсэл).

РАДИОГРАММ радиогоор дамжуулсан мэдээ.

РАДИОСТАНЦИ авиа болон чимээ зэргийг радиогоор дамжуулах ба хүлээн авах станци.

РАДИОТЕЛЕГРАММ радиогоор дамжуулсан цахилгаан мэдээ.

РАДИОТЕХНИК 1. цахилгаан техникийн судлалд буй радиогийн тухай бүлэг; 2. мөнхүү радиогийн техникийн **ухаанд мэрэгжсэн хүн.**

РАДИУС хигээс.

РАЙОН 1. аль нэг онцлог шинжээр тодорсон газар; *нүүрсний район* 2. хавь, орчим.

РАМ I у р г а м а л чулуун хөгцний адил болоод маш нарийн, түрүү гарсан хойноо хөгцийн өнгө улам гүн болдог нэг зүйл ургамал, мөн модны шүүсээр хийсэн гүн хөх өнгийн будаг,

РАМ II жааз; *зүргийн рам.*

РАПОРТ 1. цэргийн дарга нар ахмад тушаалтанд биечлэн айлтгасан албан мэдээ; *рапорт өгөх;* 2. өөртөө оногдсон үүргээ амжилттай биелүүлсэн тухай илтгэл.

РАХ нэг зүйл од: рах барих (нар сар хиртэх).

РАХУ рах.

РАШААГНАХ шашны ёсонд рашаанаар шүршиж ариутгах.

РАШААН 1. эрдэст ус; *халуун рашаан; Хужиртын рашаан;* **рашаан хур** (намираа бороо); **рашаанд орох** (рашаанд суух); 2. шашны ёсны үлээж тарнидсан ус; 3. цэцэг өвчний зайлуулсан нэр; *улаан рашаан; цагаан рашаан.*

РАШААНТАХ цэцэг өвчин хүрэх.

РЕАЛИЗМ амьдралын бодит үнэнийг хэв шинжит дүрээр нь үнэн бөгөөд бүрнээ дүрслэн үзүүлэхийг үндсэн зорилго болгосон урлаг, утга зохиол дахь зонхилох чиглэл *социалист реализм.*

РЕАЛИСТ реализмыг баримтлагч; *реалист зохиолч.*

РЕДАКТОР хэвлэгдэх зүйлийг засварлан хянагч; *хариуцлагатай редактор.*

РЕДАКТОРЛОХ хэвлэгдэх зүйлийг засварлан хянах; *ном редакторлох.*

РЕДАКТОРЛУУЛАХ редакторлохын үйлдүүлэх хэв.

РЕЗИН каучук боловсруулан хийсэн зөөлөн сунах эд; *резин бөмбөг; резинэн дугуй.*

РЕКОРД ажил, тэмцээнд олсон ололт амжилтын дээд зэргийн үзүүлэлт; аврага; *хөдөлмөрийн рекорд; биеийн тамирын рекорд.*

РЕКТОР их сургуулийн захиргааны удирдлагыг эрхэлсэн хүн; их сургуулийн ректор; *ректорын газар.*

РЕНТГЕН: рентгений цацраг тунгалаг биш юмыг нэвтлэн гаргах, цахилгаан соронзны богино долгио болох, нүдэнд үл үзэгдэх цацраг; *рентгений тасалгаа.*

РЕНТГЕНГРАФИ тунгалаг биш юмны дотоод байдлыг рентген цацрагаар зураг авах.

РЕНТГЕНЧ рентгений сургаал ба рентген заслын мэргэжилтэн; *рентгенч эмч.*

РЕНТГЕНГРАММ рентген цацрагаар авсан гэрэл зураг.

РЕСТОРАН зоогийн газар; *Туул ресторан.*

РЕФЕРЕНТ аль нэгэн тодорхой асуудлаар илтгэх, зөвлөлгөө өгөх ажилтан; *соёл гэгээрлийн ажлыг эрхэлсэн референт; сайдын референт.*

РЕФЛЕКС гадаад орчны сочролоос шалтгаалж амьд бие махбодоос өөрийн эрхгүй өгөх хариу; *болзолгүй рефлекс; болзолт рефлекс.*

РИВААДИ сарны зурхайн ёсны хорин найман одны нэгийн нэр.

РИД шашны ёсны шид, хувилгаан; **рид шид** х о р ш . .

РОВААГИНЬ сарны зурхайн хорин найман одны нэгийн нэр.

РОЙД гурилыг чихэр тостой сүүгээр өтгөн зуурч хайрч болосруулсан идээ.

РОЛЬ 1. жүжигт гарах дүр; *Балганы рольд тоглох;* 2. үүрэг; *ажилчин анхийн роль; энэ ажилд ямар ч роль гүйцэтгүй байна.*

РОМАН нарийн чанд зохиомж бүхий хүүрнэн өгүүлсэн том хэмжээний уран зохиол; *түүхэн роман.*

РОМАНТИЗМ арван есдүгээр зууны эхэнд урлаг утга зохиолд гарсан чиглэл, тэр чиглэл нь өнгөрсөн цаг, хуучны байдлыг магтан гоёж бодит байдлаас тасарсан ганц нэг хүнийг хэтэрхий ихээр магтан бичдэг байв

РОМАНТИКЧ романтизмыг баримтлагч.

РОРОМА а м ь т а н бие тоглойсон, хүзүүндээ уутны адил хоёр хөх ургасан, гэрэлтэй нүдтэй, урт эвэртэй, үс ба сүүл хоньтой адил нэгэн зүйл гөрөөс.

С

С үсэг, с авиа.

САА I ямар нэгэн эрхтнийг ердийн ажиллагаагүй болгох мэдрэлийн өвчин; **саа дайрах** (саа өвчин тохиох); **тал бие саа дайрсан** (тал бие нь мэдрэлгүй болсон); **саагийн гэм** (саа өвчнөөр ямар нэгэн эрхтэн нь мэдрэл муутай болох).

САА II алт мөнгөн утастай, тууз; *саа даруулах;* **саа хээтэй** (алт мөнгөн утсаар хээлсэн).

СААГДАХ 1. саах II-ын үйлдэгдэх хэв; 2. хорогдох, бага болох; **өдөр саагдах** (өдөр богиносох); **чадал саагдах** (тамир тэнхээ доройтох); **ажил саагдах** (ажил багасах).

СААД 1. үйл явдлыг гүйцэтгэхэд тохиолдох тоггор, садаа, саатуулах, үл хийлгэх зүйл; *миний ажилд саад мундахгүй юм; ном үзэхэд нь саад болж байв; саад хийх;* **саад тоггор** х о р ш . ; *санаа сайтай Монголчууд, саадыг давсан түүхтэй* (дуу); 2. замд байгаа, явах хөдлөхийг боож хаах, хариг хаалт; *саадаа давбал санаандаа хүрнэ; саад харайх; саад тавих; саад тоггор учруулах.*

СААДАГ I нумны сумыг дүрж зүүх ширэн сав: **саадаг агсах** (саадаг зүүх); *саадгаа агсаж сумаа дүрэв; нум саадгаа авав; санасан хүний сэтгэл нь нэг, саадаг нумын хөвч нь нэг* з ү й р .

СААДАГ II саамхай; *саадаг үнээ.*

СААДАГ III: **саадаг алчуур** аян явдлын хүний аяга агуулж зүүх сав.

СААДАГТ саадаг бүхий; ☆ **саадагт шоргоолж** (нисэх шоргоолж).

СААДГҮЙ саад тотгор байхгүй, саад тохиолдохгүй; *миний санасан хэрэг ямар ч саадгүй бүтнэ; саадгүй явахыг ерөөе.*

СААДТАЙ саад бүхий; *ажил хийхэд саадтай цаг; миний ажилд саадтай явдал мундахгүй байна.*

СААДХИЙЛ тотгордол.

СААДХИЙХ тотгорлох, саад учруулах.

СААЗ: сааз алт сайн тунгаагдаагүй, муу алт.

СААЛГА саах үйлийн нэр; *оройн саалгаар хүрэн үнээ алга байв.*

СААЛГАХ I саах I-ийн үйлдүүлэх хэв.

СААЛГАХ II саах II-ын үйлдүүлэх хэв.

СААЛИНЧИН саальчин.

СААЛТ I саах үйлийн нэр; саам; *өглөөний саалт; үдшийн саалт.*

СААЛТ II хасах, хорогдуулах, багасгах, богиносгох, *уяа оосрын саалт; үнийн саалт; саалт нь арай багаджээ.*

СААЛЦАХ саахын үйлдэлцэх хэв.

СААЛЬ I хулгайч нумтай адил оньс торгож шижим уяж гөрөөс явах замд тавьж хэрэглэх агнах зэвсэг; **сааль занга, сааль өөш** х о р ш.; *сааль тавих; сааль зүүх.*

СААЛЬ II 1. сүү, цагаан идээ; *сааль хураах; сааль сүү элбэг; сааль саах; сааль бэлдэхээр сав бэлд* з ү й р; 2. саах мал; *саалийн үнээ;* **саалийн мал** (саадаг мал); **саалийн хувин** (мал саах хувин).

СААЛЬДАХ саалиар ан агнах.

СААЛЬДУУЛАХ саальдахын үйлдүүлэх хэв.

СААЛЬЧИН сааль саах хүн; *саальчин хонгор бүсгүй минь саагаарай, саагаарай, малаа* (дуу).

СААМ I 1. гүүний түүхий сүү; *гүүний саам;* 2. нэг удаа саасан сүү; *нэг саам сүү;* **саам болох** (саах цаг **болох**).

СААМ II: **арга саам** юухан хээхнээр оролдож цаг өнгөрүүлэх, зайлсхийх, мултрах; **арга саам хийх** (аргалан мултрахыг оролдох).

СААМГАЙ саалгаж сурсан, саалгадаг; *саамгай үнээ; саамгай гүү.*

СААМГАНАХ маасганах, сэртэндэх, аалигүйтэх.

СААМГАНУУЛАХ саамганахын үйлдүүлэх хэв.

СААМГАР 1. маасгар, сэртэгнүүр; 2. маазгар, алиархаг.

СААМХ: саамх загас а м ь т а н далайд төрдөг, урт нь хоёр метр орчим нэгэн зүйл загас.

СААМХАЙ саамгай.

СААМШИХ хөх дэлэн дотор сүү ихээр хуралдах; *хүрэн үнээ бүр саамшихжээ, сүү нь дусалж байна.*

СААМШРАХ саамших.

СААМШУУЛАХ саамшихын үйлдүүлэх хэв.

СААР I муу, муухан; *сайн явахад садан олон, саар явахад дайсан олон; саар ихээс сайн бага нь дээр.*

СААР II: **аар саар** бага сага, юухан хээхэн.

СААРАГ 1. саар, сааруу; 2. саарахдаа хялбар; 3. цөөн, энд тэнд.

СААРАЛ үнсэн буюу зэвхий өнгө зүс; *саарал морь; саарал өнгөтэй даавуу; цагаан саарал; хөх саарал; зэвхий саарал.*

СААРАХ 1. харих, баахан сулрах; *уяа саарах; гэрийн бүслүүр саарчихжээ;* 2. ш и л ж с э н буурах; нугарах, намжих; *халууны илч саарах; өвчин нь саарчээ;* 3. шантрах буцах; *зориг нь саарах; хүч нь саарах.*

СААРГҮЙ эрхгүй, аргагүй, эрхбиш, заавал, зайлшгүй, саадгүй; *сааргүй хүрэлцэн ирнэ үү; сааргүй бүтнэ гэж бодож байна.*

СААРМАГ 1. зарим амьтанд эр эм хоёр бэлгийн эрхтэн хоёул бүхийг; ☆ **саармаг үсэг** (эр эм үгэнд хоёуланд нь хэрэглэгдэх эгшиг үсэг-И); 2. тээнэгэлзмээр, шийдвэргүй, тогтворгүй; **саармаг явдал** (шийдвэргүй, хоёрын хооронд); **солиг саармаг** (ташаа, буруу зөв нь мэдэгдэхгүй).

СААРМАГЛАХ саармаг болох, санаа эргэлзэн тээнэгэлзэх, шийдвэрлэж чадахгүй байх; *саармаглаж сууж цаг алдсанаас түргэн шийдвэрлээл ашигтай.*

СААРМАГЛУУЛАХ саармаглахын үйлдүүлэх хэв, саармаг болгох.

СААРМАГТАХ санаа хэлбэлзэн, шийдэж чадахгүй байх; *хоёрын хооронд саармагтах хэрэг алга, шийдсэн дээр.*

САРУУ сарараг байдалтай, зориггүй, шантрамхай; **сарууу баруу** х о р ш . .

САРУУЛАХ сарахын үйлдүүлэх хэв, хойшлуулах, болиулах.

САТАЛ саатах үйлийн нэр, саад учирсан нь; *саатал их тохиолдсонгүй.*

САТАХ I 1. ажил явдалд саад тохиолдох; *бид замдаа саатав; хэд хоног саатах; бороонд саатав;* 2. эрхлэх, наадах, биеэ зугаацуулах; *хүүхэд саатаж байна;* 3. хүндэтгэвэл зохих хүн нэгэн газар байзнах, түдэх; *та тайван саатаж байна уу?*

САТАХ II саа өвчин тусах.

САТУУЛАХ саатахын үйлдүүлэх хэв, саад учруулах, зугаацуулах, түдүүлэх; *хүүхэд саатуулах газар байгуулах.*

САХ I хөхийг шувтарч сүүг гаргах; *хонь саах; ингэ саах;* ☆ **саах тавих** (саахалтын хоёр айл, хурга ишгээ харилцан зөрүүлж хониндоо нийлүүлэн хариулах); **гүү саах** (хэд хэдэн ширхэг юмыг дээш шидэж самбаатай барьж авах нэгэн зүйл наадам).

САХ II 1. уртыг охор болгох, богиносгох, холыг ойр болгох; *уяагий нь саах; газрын хэмжээг саах;* 2. ш и л ж с э н юмны үнийг хорогдуулах, хямдруулах; *үнэ саах.*

САХ III тийм их юмгүй; *над юм саах юм байхгүй; туршлага саах юм над байхгүй.*

СААХАЛТ саах тавьж болмоор ойрхон буусан хоёр айл; *саахалт айл; тэдний манайхан саахалт; саахалтын газар; саахалтын айлаар бууж мордоод ирэв; айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг* з ү й р ; ☆ **саахалт одод** (одны орд).

САВ I юм агуулахад зориулсан зүйл; *аяга сав; сав суулга; сүү авах гэсэн сав байхгүй; хүүдий сав; байшин сав; бичгийн сав; барьдаг сав; сархад гэдэг идээ чинь савнаасаа бусдыг дийлнэ* з ү й р ; **голын сав** (ус урсах газар; *голын ус савнаасаа халив);* **голын сав газар** (голын хоёр талын дагуу орчин газар); ☆ **сав зэвсэг** (гэр орны бүх хэрэглэгдэхүүн); **таван сав** (таван цул).

САВ II умай; *савны өвчин; сав агших.*

САВ III: **сав ертөнц** амьгүй буюу бодисын ертөнц, бас гадаад ертөнц ч гэнэ; **савын бодис** (амьгүй бодис); **сав шимийн бодис** (амьгүй, амьтай бодис).

САВ IV төлөв, оюун, билэг; **сав тэнцүүлэх** (эрдмийг тэнцүүлэн албаная хэрэглэх); **сав сайтай** (оюун сайтай).

САВ V: **сав үсэг** төвдийн нэг зүйл үсэг.

САВ VI Са-гаар эхэлсэн үгийн өмнө тавих хүч нэмэгдүүлэх үг; *сав саяхан.*

САВАА юм савах нарийн мод; *бургасан савааа; сухай савааа; савааа шандас; ноос мяндас* (ноос савж байгаа хүнд хэлэх ерөөл):.

САВААГҮЙ I энэ тэр юманд хүрэх, оролцох халдах зантай; *яасан савааагүй юм бэ! савааагүй нохой саранд хуцах* з ү й р ; ☆ **таван савааагүй** (ариун цэврийн таван зүйл хэрэглэл).

САВААГҮЙ II саваадаагүй, савсан бус; *савсан савааагүй ноос хольсон байна.*

САВААГҮЙТҮҮЛЭХ савааагүйтэхийн үйлдүүлэх хэв.

САВААГҮЙТЭХ савааагүй зан ааль гаргах.

САВААДАХ савааагаар дэлдэх, цохих; *дээл савааадах.*

САВААДУУЛАХ савааадахын үйлдүүлэх хэв.

САВАГ саваа.

САВАГДАХ савахын үйлдэгдэх хэв.

САВАН юм уғаахад хэрэглэх, усанд хайлах, өөх тос ба шүлтээр бүтсэн хатуу буюу нялцгай зүйл; *барааны саван; нүүр гарын саван; сахлын саван; савангийн хөөс; савангийн завод.*

САВАНДАХ саван түрхэх, савангаар угаах; *савандаж угаах; гараа савандах.*

САВАНДУУЛАХ савандахын үйлдүүлэх хэв.

САВАР 1. хумстайгаа хөл; *бургэдийн савар; баавгайн савар;* 2. аргал мэтийг түүх, хамах ац, салаатай хэрэгсэл; *цаад хогоо савраар хам!* 3. өвсний ац.

САВАРДАХ 1. савраар хамах, түүх, цохих; *аргал савардах;* 2. савраар шүүрэх, самардах, базах.

САВАРДУУЛАХ савардахын үйлдүүлэх хэв.

САВАХ 1. цохих, дэлдэх, гуядах; *унгас савах; дээл савах;* 2. хавтгай юмаар хүчтэй цохих, дэлдэх; *ханцуйгаар савах; хаалга савах магадгүй;* 3. босоо юм гуядаж унах; *савж ойчих;* 4. гуядан шидэж унагаах; *савж орхиод явчих.*

САВГА сарлагийн хэжлүүрийг дагаж ургасан урт ус, хэжим; сарлагийн савга; *савгын хялгас.*

САВГАДАХ I сарлагийн савгаас шүүрэх, барих.

САВГАДАХ II гээсэн юмыг олон хүн зэргээр шимтэн эрэх.

САВГАЛАХ сарлагийн савгыг хайчлан авах.

САВГҮЙ 1. төлөв муу, үрэмхий; 2. оюун ухаан болхи.

САВДАА самбаа, завдаа, сэхээ.

САВДААГҮЙ сэхээ самбаа муутай.

САВДААТАЙ самбаатай, завдаатай, сэхээтэй.

САВДАГ I ш а ш и н газар орны эзэн.

САВДАГ II: **савдаг элээ** саваагүй, юм юманд хүрэлцэх оролцох зантай; *савдаг зантай; савдаг элээ шиг хаашаа хүн бэ.*

САВДАГЛАХ савдаг, саваагүй зан гаргах.

САВДАХ савдаг зан гаргах, самбаа ихтэй, энэ тэр юманд хүрч завдах.

САВДГАНУУР энэ тэр юманд хүрэх, халдах байдалтай.

САВИРАХ шингэн юмны дусалж гоожих, цуврах; *шээс савирдаг өвчинтэй; шүлс савирах.*

САВИРУУЛАХ савирахын үйлдүүлэх хэв.

САВЛАХ I саванд хийх, агуулах; *гурил савлах; сүү савлах.*

САВЛАХ II байн байн савлах.

САВЛАХ III зах зааг нийлэх *нутаг савлах.*

САВЛУУЛАХ савлахын үйлдүүлэх хэв .

САВЛУУР савалдаг юм; *савлуур дээр савах; савлуурын сэнж.*

САВСАГ 1. тогтсон чиггүй, юм юманд хүрэх, оролцох зантай; 2. хээнцэр, завхай, самуун.

САВСАГЛАХ савсаг зан байдал гаргах.

САВСАХ уур, утаа зэргийн ихэд оргилох; *уур савсах; тамхиа татахад хамраар нь утаа савсаж байв.*

САВСЛАГА 1. юмыг хоёр этгээдээс хавчин бариулахаар хийсэн багаж; *адуу агтлах савслага; номын савслага;* 2. х у у ч и р с а н манжийн хуулийн есөн эрүүгийн нэг; 3. х у у ч и р с а н эхнэр хүнийг ичээхэд хэрэглэх таван ширхэг савх мод.

САВСЛАГАДАХ 1. савслагаар хавчих, бариулах; 2. х у у ч и р с а н савслага эрүү тулгах.

САВСЛАГАДУУЛАХ савслагадахын үйлдүүлэх хэв.

САВСЛАГАЛАХ савслагадах.

САВСЛАХ байн байн савсах.

САВСЛУУЛАХ савслахын үйлдүүлэх хэв.

САВСУУЛАХ савсахын үйлдүүлэх хэв; *утаа савсуулах; уур савсуулах.*

САВТАРХАЙ навтархай; **савтархай навтархай** х о р ш.

САВУУЛАХ 1. савахын үйлдүүлэх хэв, савахад хүргүүлэх; 2. савагдах.

САВХ 1. хоёр нарийн урт яс буюу хулс зэргээр хийж хоол хавчин этэж идэх хэрэгсэл; *ясан савх;* **савхын хоног** (хутганы хуйн савх дүрэх газар); **савх мод** (бага ангийн сурагчид тоолж тоо бодох жижиг мод); 2. байшин барилга шавардахад хананд хадах нарийн цуудас мод; *савх хадах;* 3. ховил гаргасан хоёр банзны хоорондхавчуулан бэхлэх нарийн зурвас мод; *савх шаах.*

САВХАН с а в х а н х у в и н нэгэн зүйл хувин; *гуулин савхан; алаг савхан;* **савхан өвс** у р г а м а л (нэг зүйл бамбай).

САВХАНЦАР савхан хэлбэртэй нян; *дуран байд савханцар үзэгдэв.*

САВХДАХ савхаар юмыг хавчин авах буюу этэх; *хоол савхдах.*

САВХДУУЛАХ савхдахын үйлдүүлэх хэв.

САВХИ (Н) I хонь, ямаа зэрэг амьтны боловсруулсан арьс; *савхин дээл; савхин бээлий; савхин гутал.*

САВХИ II: **савхи цэцэг** у р г а м а л уулын цайны цэцэгтэй адил цэцэгтэй, тоорцог нь цагаан болоод дүгрэгхэн, үнэр ихтэй, хаврын эцсээр цэцэглэнэ.

САВХЛАХ 1. савхдах; 2. шавардахаар савх хадах; 3. заадас тав юманд савх зуулгах.

САВХЛУУЛАХ савхлахын үйлдүүлэх хэв.

САВХРАХ юмны савх мэт ширхэгтэй болох; *мөс савхрах.*

САВЧИХ 1. савж орхих, савж унагах; 2. байн байн сáвах; *ханцуйгаараа савчих.*

САВЧУУЛАХ савчихын үйлдүүлэх хэв.

САВЧУУР тогтворгүй дэдэгнүүр зан байдалтай; *савчуур хүн.*

САГ I хорхой шавьж, ялаа батганын өндөг; *саг орхих.*

САГ II хог; **хог саг** х о р ш.

САГА: **бага сага** бага зэрэг; *бага сага юм авав; над бага сага ажил эмхлүүлэх хэрэг байна.*

САГАГ I у р г а м а л үрээр нь хэмхдэг, гурил хийх хөдөө аж ахуйн өвсөрхөг ургамал, гурвалжин будаа; *сагагийн агшаамал; сагагийн гурил; сайн муу хоёр талтай, сагаг будаа гурван талтай* з ү й р.

САГАГ II саглага.

САГАДАЙ сагаг.

САГАЛДРАГА 1. малгай, дуулга, хазаар мэтийн эрүүний доогуур оруулан торгох уяа, сэгэлдрэг; *малгайн сагалдрага; хазаарын сагалдрага;* 2. сэгэлдрэг; *унийн сагалдрага; ташуурын сагалдрага.*

САГАЛДРАГАЛАХ сагалдрагаар уях, торгох, сэгэлдрэглэх; *малгайгаа сагалдрагалах.*

САГАЛДРАГАЛУУЛАХ сагалдрагалахын үйлдүүлэх хэв, сэгэлдрэглүүлэх.

САГАХ 1. хөөрөн сагсайж асгарах; *хувинтай тараг сагаад амаараа асгарч байна;* 2. ш и л ж с э н хэтэрхий цадаж амаар буцаж гарах гэж байх мэт болох; *хоол сагах;* 3. ш и л ж с э н давлиун, дээрэнгүй зантай болох; *зан нь сагах; сагасан залуу байна даа.*

САГЛАГА адууны бэлбэрхийн хойтох урт үс; *морио чөдөрлөх гэж саглага дээрээс нь барьж хөлий нь ойртуулав.*

САГЛАГАР 1. навсгар, нэвсгэр; *саглагар гэр; саглагар үхэр;* 2. навч нахиа, мөчир салаа ихтэй; *саглагар саглагар модонд шаазгай шувуу донгодно хөө* (дуу).

САГЛАЙЛГАХ саглайхын үйлдүүлэх хэв, саглагар болгох.

САГЛАЙХ саглагар болох.

САГНАХ утаж ариулан ариутгах.

САГС хулс зэгс, дэрс зэргээр сүлжиж хийсэн сав, сэвэг; *зэгсэн сагс; дэрсэн сагс;* ☆ **сагс бөмбөг** (баганад өлгөсөн сагс мэт торонд бөмбөг оруулан тоглох нэг зүйл наадам).

САГСАЙЛГАХ сагсайхын үйлдүүлэх хэв, сагсгар болгох.

САГСАЙХ 1. сагсгар болох; *ус сагсайх;* 2. зарим юмны исч сагах, хөөрөх; *тараг сагсайх; бүсгэсэн будаа сагсайх.*

САГСАЛЗАХ сагсгар юмны байн байн сагсас сагсас хийж хөдлөх, сэгсэлзэх; *ус нь сагсалзах.*

САГСАЛЗУУЛАХ сагсалзахын үйлдүүлэх хэв, *шанам малгай сагсалзуулах...*

САГСГАНАХ сагсгар юмны үргэлжлэн сагсга сагсга хөдлөх; *ус сагсганах; зогдор сагсганах.*

САГСГАНУУЛАХ сагсганахын үйлдүүлэх хэв.

САГСГАР 1. арзайж өрвийсөн, арзгар өрөвгөр; *сагсгар ус; сагсгар бут;* 2. навч нахиа, мөчир салаа ихтэй; *сагсгар мод уулын чимэг, сайхан хүүхэн гэрийн чимэг* з ү й р.

САГСРАГА юман дээр бууж устсан жихүүн уур; сагшуурга ч гэдэг; *өвсөн дээр сагсрага суугаад хүйтний шинж орж байна.*

САГСРАХ санааны зоргоор хэв журмыг зөрчиж түйвээн явах.

САГСУУ хөөрхөг зантай, хөөргөн, онгиргон.; *сагсуу хүн.*

САГСУУРАХ сагсуу зан байдал гаргах.

САГСУУРУУЛАХ сагсуурахын үйлдүүлэх хэв.

САГУУЛАХ сагахын үйлдүүлэх хэв.

САД I шингэн үүрмэг зүйлийн гэнэт цувран гарах байдлыг үзүүлнэ; *сад тавих; хамраас цус сад хийх; савтай будаа сад асгарав.*

САД II цаг; *алтан сад; мөнгөн сад.*

САДАА саад тотгор; *садаа болох ажил бүү хий!*

САДААГҮЙ садаа, тотгор байхгүй, учрахгүй.

САДААЛАХ садаа болох, садаа учруулах.

САДААРАХ 1. садаа тохиолдох, учрах; 2. саатах, удаашрах.

САДААТАЙ садаа тотгор бүхий, садаа хийж байдаг.

САДААТАХ садаалах, саад тавих.

САДАГНАХ садан төрлийн дотор дотнолон төрөлсөж явах.

САДАН хамаатан, төрөл; **садан төрөл** х о р ш.; *холын садан; эцгийн садан.*

САДАР самуун, завхай, шалиг; **садар самуун** х о р ш.; *садар самуун явах;* ужид садар ч гэдэг; *садар самуун яваагүй бол сайнаас ягаад салах вэ хөө* (дуу).

САДАРЛАХ садар самуун явах, завхайрах.

САДАРХАЙ I зүрх уушиг өлэг гурвын нийлсэн уулзрын газар.

САДАРХАЙ II нэг цэгээс садран гарсан гэрэл, шугам зэрэг юм.

САДАРХАХ садагнах, төрөлсөх.

САДАРХУУЛАХ садархахын үйлдүүлэх хэв.

САДВИС з у р х а й сарны зурхайн ёсны хорин найман одны нэгийн нэр.

САДГА I садаа.

САДГА II х у у ч и р с а н бөө нарын онгод ороход өлгөх цаасан хүний дүрс.

САДГАЛАХ садга болох, тотгор болох.

САДГАНАХ I тавтиргүй зан байдал гаргах.

САДГАНАХ II юмны садран асгарах, гоожих.

САДАГНУУЛАХ садганахын үйлдүүлэх хэв.

САДГАТАХ садгалах, тотгор болох

САДРАХ шингэн зүйл хүчтэй гоожих; *шархнаас цус садрав.*

САДРУУЛАХ садрахын үйлдүүлэх хэв.

САЖИН 2, 13 метртэй тэнцүү уртын хэмжээ.

САЖИХ хоёр тийш хөдөлгөх, займрах, савлах, сэгсрэх; *толгой сажиж, үгүй гэв; гар сажиж, дуугай бай гэсэн дохио өглөө; ханцуй сажин гарч одов.*

САЖИЦ 1. гар сажих, завсрын хэмжээ; 2. сажих хөдөлгөөний далайц, завсрын хэмжээ; *дүүжингийн гуйвалтын сажиц.*

САЖЛАХ I 1. алгуур алхаж явах; *морь нь сажилж явав; санаж явбал бүтдэг, сажилж явбал хүрдэг* з ү й р. 2. ш и л ж с э н арайхийн амьдрах.

САЖЛАХ II байн байн сажих; *гараа сажлах.*

САЖЛУУЛАХ сажлахын үйлдүүлэх хэв; *бүрхэг хулаа унаж сажлуулсаар явлаа.*

САЗ юмыг цэвэрлэх, үрэх зэрэг зүйлд зориулж шүүр гарган хийсэн хавтгай төмөр.

САЗДАХ сазаар үрэх, цэвэрлэх.

САЗДУУЛАХ саздахын үйлдүүлэх хэв.

САЙ I сая II.

САЙ II ус урсч байсны орон мэдэгдэхүйц газар, сайр.

САЙВАН хувцас хунар үйлдвэрлэх оёдолчин, үйлчин; *сайван хийсэн дээл.*

САЙВАР адууны жороотой адил боловч бага алгуурхан явах явдал; *сайвар морь.*

САЙВАРЛАХ морины сайвар явах.

САЙВАРЛУУЛАХ сайварлахын үйлдүүлэх хэв.

САЙД улсын яамыг толгойлон удирдах засгийн газрын гишүүн хүний албан тушаал; *сангийн яамны сайд; орлогч сайд;* ☆ **ерөнхий сайд** (улсын тэргүүлэгч, сайд нарын зөвлөлийн дарга); **элчин сайд** (улсаа төлөөлж харь улсад суух сайд).

САЙДАХ 1. сайны учир тохиромжгүй болох, хэтэрхий сайн болох; 2. сайжирч сайн болох.

САЙДУУЛАХ сайдахын үйлдүүлэх хэв.

САЙЖРАЛ сайжрах үйлийн нэр.

САЙЖРАХ сайн болох, дэгжих, дээшлэх; *ажил нь сайжрав; зан сайжрах; орос хэлэнд нилээд сайжирсан байна.*

САЙЖРУУЛАХ сайжрахын үйлдүүлэх хэв, сайн болгох.

САЙМСАРЧ хуурмагаар зулгуйдаж дотно сайн байгаа байдал үзүүлэгч.

САЙМСРАХ зулгуйдах, зусар зулгуй зан гаргах.

САЙМШРАХ зулгуйдаж дотно сайн байгаа шинж гаргах.

САЙН муугийн эсрэг утга; 1. зохистой, тохиромжтой, яс, чанартай; *хүний сайныг ханилж мэд, хөлгийн сайныг унаж мэд; эдийн сайныг эдэлж мэд* з ү й р; *сайн юманд эзэн*

олон, сайн нөхөрт хань олон з ү й р; **сайн зан** (аятай, нийлэмж сайтай зан); **сайн бөх** (чадал тэнхээ ихтэйгээрээ алдаршсан бөх); **сайн ажилчин** (үнэхээр идэвх зүтгэл гаргаж үр бүтээлтэй ажилладаг ажилчин); **сайн дур** (өөрийн дур санал); **сайн нөхөр** (дотно нөхөр); **сайн үйл** (зөв үйл); **сайн санаа** (туст санаа); **хамгийн сайн** (дээд сайн); **сайн хүн** (нөхөрсөг тусч хүн); **сайн угсаа** (сайн үүлдэр); 2. ш и л ж с э н мэнд амар, тайван, зовлон зүдүүргүй; *сайн сууж байгаарай! бие сайн уу? сайн, та сайн байна уу?* **амар сайн уу?** (золгоход хэлэх мэнд); **сайн нойрсов уу?** (боссон даруйд учран, мэндлэх үг); 3. олигтой, зэгсэн, үлэмж; *юм сайн уугаарай, цангана шүү; сайн болгоомжсл! сайн явбал өдөртөө хүрнэ;* ☆ **сайн өдөр** (а. аливаа үйл хийхэд зохих өдөр; б. амралтын өдөр, Ням гараг); **сайн сархинаг** (муу сархинагийн хажууд наалдан байх гүзээ мэт жижигхэн эрхтэн); **сайн данхар** (цэцэн тотийн өөр нэр).

САЙР I жижигхэн хайр чулуу бүхий газар; *голын сайр; усны сайр; сайр шандын усыг шавхаж аваад барахгүй, сайн хүний үрийг шоолж муулавч болохгүй* (дуу).

САЙР II ямаа, хонины боловсруулсан өнгөт арьс.

САЙР III биеийн арьс хатаж, хаг буртаг суусан ширүүн баргар; *сайр идэх; гарын сайр.*

САЙРАРХАГ сайр ихтэй; *сайрархаг газар.*

САЙРАХ сайн тийш болох, сайжрах.

САЙРДАХ хэтэрхий сайртай болох.

САЙРТАХ сайр тогтох, сайртай болох; *дулаан цагт үргэлж хөл нүцгэн явсаар хөл нь сайртжээ.*

САЙРТУУЛАХ сайртахын үйлдүүлэх хэв.

САЙРХААЧ сайрхагч.

САЙРХАГ 1. сайрхах зантай; бардам; 2. зулгуйч, зусар зантай.

САЙРХАГЧ сайрхаан, зуйрган, зулгуйч зантай.

САЙРХАЛ сайрхах үйлийн нэр, гайхуулал, бардамнал, саймсрал.

САЙРХАХ 1. сайнаа гайхуулах, бардамнах; *сайрхаад байсан, аль вэ!* 2. саймсрах, сайн гэж үзэгдэхийг хичээх.

САЙРХУУЛАХ сайрхахын үйлдүүлэх хэв.

САЙТАЙ 1. сайн чанар бүхий; *чанар сайтай эд;* **мөс сайтай хүн** (ханилгаа сайтай); **хүн сайтай** (нөхөрсөг тусчхан); *замаг сайт усанд шувуу болгон цугладаг, зан сайт хүнд хүн болгон цугладаг* з ү й р; 2. ихтэй, үлэмж; *сүү сайтай үнээ; өвс сайтай нутаг; тослог сайтай хоол; мал сайтай айл.*

САЙТАР сайн, машид, ихэд; *сайтар болгоомжлох; сайтар захих; сайтар боловсруулах.*

САЙХАЛЬ у р г а м а л бут бутаар ургадаг, салаа найлзуур **зөөлөн**, сондуутай, иш нэгтэй боловч цэцгийн **өнгө** янз бүр, нэг хүйст **өнгө** холимог ч байдаг.

САЙХАН муухай гэдгийн эсрэг утга; 1. **юм**ны овор дүр, яс чанар өнгө зүс хээ үзэмжтэй, аятай; *сайхан хот; сайхан хүн; сайхан морь; сайхан газар; сайхан үнэр; сайхан хоол;* **уран сайхан** (а. урлаг урлагийн ажилд хамаарагдах, холбогдох зүйл: *театрын уран сайхны удирдагч;* б. бодит явдлыг дүрслэн үзүүлсэн кино, зохиол зэрэг; *уран сайхны кино);* **гоо сайхан** (урлаг, уран сайхны **тухай** сургаал); 2. зохистой, нийлэмжтэй, тохиромжтой; **тэнгэрийн сайханд** (бороо, шуургагүйд, **цэлмэгт**); **цаг сайхан байна** (ган зудгүй); 3. сэтгэл санааны хоргүй, шудрага; *сайхан сэтгэлтэй хүн; сайхан зантай авгай;* **сайхан хэвт цэцэг** у р г а м а л (иш навч замар цэцгийн адил, гагцхүү цэцгийн өнгө шар, хүйс нь том, гилтэгнэм үзэсгэлэнтэй).

САЙХИ мөнөөх, өнөөх; *сайхи хүмүүс ийм хэлсэн ажээ; сайхи учрыг эс мэдэв.*

САЙЧУУД олон сайн, сайчуул; *хөдөө аж ахуйн тэргүүний сайчуудын анхдугаар зөвлөгөөн болов.*

САЙЧУУЛ сайчууд.

САЙШААГДАХ сайшаахын үйлдэгдэх хэв.

САЙШААЛ сайшаах үйлийн нэр; *сайшаалын үнэмлэх бичиг; сайшаал хүлээх;* **сайшаалын бичиг** (гавьяа зүтгэлийг тэмдэглэж дурсгал болгон хадгалуулах бичиг).

САЙШААЛГАХ 1. сайшаахын үйлдүүлэх хэв; 2. сайшаагдах.

САЙШААЛТАЙ сайшаавал зохих; *сайшаалтай хэрэг.*

САЙШААХ магтах, сайн гэж хэлэх, сайныг гэмдэглэх; *сайшаавал зохихоор ажиллажээ; тийм хүнийг сайшаах хэрэгтэй.*

САКС: сакс **бүрээ** үлээвэр хөгжмийн нэг зүйл зэбсэг.

САКСФОН сакс бүрээ.

САЛ I усаар урсгах буюу усан дээр явахаар урт бүдүүн моднуудыг зэрэгцүүлэн бэхэлж үйлдсэн зүйл; *сал урсгах; салаар явах.*

САЛ II: **сал сул** хөнгөн хуумгай, салан задгай; *сал сул хүн дээ.*

САЛ III: **сал хийх** бие яндангиран суларч салдасхийх.

САЛ IV: **сал мод** у р г а м а л нарийн агар модны навчтай адил, навчтай, цагаавтарханд дүрстэй нэгэн зүйл мод, шувуу суудаггүй, хорхой төрдөггүй маш ариун мод гэдэг.

САЛАА 1. салбарласан юм, нэг юм ац гаран салсан нь; *модны салаа; голын салаа; салахын эрхээс эс салав, салаа замын эрхээр салав;* 2. нэгэн иш угаас салбарлан гарсан юмны хоорондох завсар; *хуруугны салаа; салаа гарах;* 3. цэргийн сумангийн доторхи жижиг анги; *нэг салаа цэрэг явсаар байв; салааны дарга; салааны туслах.*

САЛААЖИХ салаа олонтой болох.

САЛААЛАХ 1. салаатай болох; *салаалж урсах; салаалж ургах;* 2. нэг уяа, гогцоогоос хоёр юмыг уяж торгох; *морцо салаалж аргамжив.*

САЛААЛУУЛАХ салаалахын үйлдүүлэх хэв.

САЛААРАХ салаатай болох, салаа гарах.

САЛААТАХ 1. салаа гарах, салаалах; *мод салаатах;* 2. ш и л ж с э н ац учир шалтгаан гарах; *хэрэг салаатах.*

САЛАЙ малын умайгаас гарах наалданги шингэн юм.

САЛАЛГҮЙ үргэлж, ямагт, нэгэн хамт; *салалгүй дагах.*

САЛАЛЖ I а м ь т а н зарагтай адил байдалтай, сүүлийн язгуур нь цагаан нэг зүйл шувуу.

САЛАЛЖ II худраганы язгуурт хадаж, угцуурганд уях дөрвөн бэлчин; *худраганы салалж.*

САЛАЛТ салах үйлийн нэр; *салалт гэрлэлтийг бүртгүүлэх.*

САЛАЛЦАХ салахын үйлдэлцэх хэв.

САЛАМ хүч нэмэгдүүлэх үг; *салам цохих; салам татах.*

САЛАМГАНАХ саламгар юмны саламга **саламга хийх.**

САЛАМГАР урагдаж элэгдсэн, навтарсан юм.

САЛАМЛАХ салмарахад хүрүүлэх, саламгар болгох.

САЛАН осол, задгай, назгай, нягт нямбай биш; *салан хүн;* **салан задгай** х о р ш.; ☆ **салан шувуу** (хөхөө шувуу).

САЛАНГАД хамт биш, саланхай, тус тус.

САЛАНГИ хоёр хэсэг, саланхай, салангад.

САЛАНГИДУУ арай саланги, арай салангад.

САЛАНХАЙ нэгэн хамт биш, тус тус салсан нь; *миний үзэг иш хоёр саланхай хэвтэж байна; манай хонь ямаа саланхай бий.*

САЛАХ 1. хамт биш болох; *хоёр тийшээ салах; нэг мөчир нь салаад ойчжээ;* 2. ангижрах, хагацах; *төвөгтэй ажлаас салахыг ороддов; салах ёс гүйцэтгэв; сайн нөхрөөс салав; өвчнөөс салах; өрнөөс салах;* 3. ханилан суухыг болих; *эхнэрээсээ салсан ажээ;* 4. аливаа үйлийн бүрмөсөн төгсч шийдвэрлэсэн утга; *өгч салах; авч салах; хэлж салах.*

САЛБА I у р г а м а л лонх хэлбэртэй нэгэн зүйл жимс.

САЛБА II эндүүрэмтгий, мэдэмхийрэн ярьдаг; *салба хүн.*

САЛБАГАНАХ салбагар юмны үргэлжлэн салбага салбага хөдлөх; *урд хормой нь салбаганан хөдөлж байв.*

САЛБАГАНУУЛАХ салбаганахын үйлдүүлэх хэв.

САЛБАГАР 1. нэвсгэр, унжин санжин болсон нь; *салбагар цув; салбагар дээвэр;* 2. урагдаж ноорсон, навтарсан нь

САЛБАГАРДАХ хэтэрхий салбагар болох.

САЛБАДАЙ маш эндүүрэмтгий, мэдэхгүй мөртөө мэдэмхийрэн дэмий ярьдаг заншилтай.

САЛБАДАХ 1. салбах; 2. эндүүрэх.

САЛБАДУУЛАХ салбадахын үйлдүүлэх хэв.

САЛБАЙЛГАХ салбайхын үйлдүүлэх хэв, салбагар болгох.

САЛБАЙХ салбагар болох.

САЛБАЛЗАХ салбагар юмны байн байн салбас салбас хөдлөх.

САЛБАН I сархинагийн доторхи олон хуудас; *сархинагийн салбан.*

САЛБАН II салан, залхуу; *салбан хүн.*

САЛБАН III 1. жанчны захын доогуурхи хэл мэт унжлага; *жанчны салбан;* 2. зарим нутагт жанчны хуниасыг ийнхүү нэрлэнэ.

САЛБАР I салаа; *замын салбар; усны салбар;* 2. шилжсэн байгууллага, газраас салж гарсан хэсэг; *эмнэлгийн салбар; үйлдвэрийн салбар; хоршооны салбар.*

САЛБАР II герөөс, шувуўны савар.

САЛБАРАХ 1. олон хэсэг цууран эвдрэх; *ташуурын үзүүр нь салбарчээ;* 2. сэмрэн урагдах; *бүс салбарч урагдав.*

САЛБАРЛАХ салбар болон гарах; *Алтай уулнаас салбарлан гарсан нуруу;*

САЛБАРЛУУЛАХ салбарлахын үйлдүүлэх хэв. салбар болгох.

САЛБАРС амьтан мөрөн тэнгэс, гол нуурын усанд байдаг, хушуу шовхгор, нуруу бөгтөр, хоёр хажуугийн дундхи журамдаа гучин зургаан хайрстай нэгэн зүйл загас, идэхэд эрхэм сайн.

САЛБАХ 1. мэдэхгүй атлаа дэмий мэдэмхийрэн хэлэлцэх; 2. хадсан өвс мэтийг газар дээр нь дэмий орхих.

САЛБУУЛАХ салбахын үйлдүүлэх хэв.

САЛГА I 1. толгой гар зэрэг эрхтэн өөрийн эрхгүй чичирхлэх мэт хөдлөх; *архинд хэтэрхий орсон үчир хундагатай архи өгөхөд гар нь салгалав;* 2. шилжсэн байсан юмаа алдаж орхидог, бүтэлгүй, чадвар дорой.

САЛГА II хөллөх, чирэх юманд хийсэн бүрхүүл.

САЛГАЛАХ 1. чичирхийлэх; *толгой нь салгалан хөдөлсөөр байв;* 2. шилжсэн дөнгөн данган амьдрах, хөдлөх.

САЛГАЛУУЛАХ салгалахын үйлдүүлэх хэв.

САЛГАМЖ нэхэх ширхгийг ташаалан хавчиж нэхэх шүүрийн мэт хэрэгсэл.

САЛГАН: үлгэн салган 1. арай ядан хөдөлж яваа; өвчинд нэрвэгдэж үлгэн салган болсон амьтан; 2. маш их салга болсон.

САЛГАНАХ багашиг салгалах, салгалан хөдлөх; *гар нь салганав.*

САЛГАНГИ саланги, саланги болгосон, саланхай.

САЛГАНУУЛАХ салганахын үйлдүүлэх хэв.

САЛГАТАХ салга болох.

САЛГАХ салахын үйлдүүлэх хэв; 1. юмыг онд ондоо болгох, тусгаарлах; *мөчрөөс нь салгах;* 2. хагацаах, юмы нь байхгүй болгох; *сайн мориноос нь салгах;* **амьдралаас нь салгах** (амьдралгүй болгох); 3. ялгах, ангилах; **ялган салгах** хорш.; *данс хараад ялган салгах;* 4. ханилан суугчдыг хагацуулах; *эр эм хоёрыг салгах; эхнэрээс нь салгах.*

САЛГУУЛАХ салгахын үйлдүүлэх хэв.

САЛДАГ салахаар хийсэн юм; *салдаг ширээ; салдаг ор.*

САЛДАЙХ бие тэнхэл муутай сул болох бие алдрах; *бие салдайгаад хөдлөх дургүй болжээ.*

САЛДАН шалдан.

САЛДАР I 1. мэдрэлийн судал; **харааны салдар** (харааны мэдрэлийн судал); 2. салаа, салбар; **салаа салдар** хорш.; *салдар зам.*

САЛДАР II: **салдар сулдар** сал сул, эрээ цээргүй; *салдар сулдар гэсэн хачин амьтан шүү.*

САЛЖИЙЛГАХ салжийхын үйлдүүлэх хэв.

САЛЖИЙХ нэг тийшээ хажуулан унах; *мод салжийж унах.*

САЛИА зунгаарч наалдангирсан нуршин улхгар юм, салай ч гэдэг; *хүүхдийн баас салиатай гарч байв.*

САЛИАЛАХ салиатай болох.

САЛИАРАХ салиа байдалтай болох.

САЛИАТАХ салиа тогтох.

САЛИУА ургамал хадан чицарганын цэцэгтэй адилавтар ногоон өнгөтэй, харавтар улаан цэцэгтэй нэгэн зүйл өвс, хавар зуны завсрын үеэр цэцэглэнэ.

САЛЛАГЧ 1. сал хийгч; 2. салаар явагч.

САЛЛАХ 1. сал хийх, сал бэлтгэх; 2. сал залж явах.

САЛМАА тураг бугын сүүлийн угт ургасан урт хар үс.

САЛМААНДАР амьтан хүүш чийгтэй газарт төрдөг, охор хөлтэй, бие нь урт, шар хар үс бидэрлэн ургасан нэгэн зүйл амьтан.

САЛМАЙХ саламгар болох.

САЛМАЛЗАХ саламгар юмны салмас салмас хийх.

САЛМАРАХ сэмэрч урагдах, ноорох, навтрах.

САЛМАРУУЛАХ салмарахын үйлдүүлэх хэв.

САЛС амьд бие махбодын зарим эсээс ялгаруулан гаргадаг залхаг, зунгаг

САЛСТ салс бүхий; **салст бүрхэвч** (амьд бие махбодын хөндий сүвтэй эрхтний дотоод талын зунгагт бүрхэвч).

САЛСТАХ салс тогтох.

САЛСТУУЛАХ салстахын үйлдүүлэх хэв.

САЛСУЛ осол цалгар, **салан** задгай, хээгүй, эрээгүй, цээргүй.

САЛТАА 1. хоёр гуяын хоорондох газар; *салтаа доогуур нь шурган гарч гэнэ;* 2. өмдний хоёр гуяын хоорондох газар; *өмд нь салтаагаараа урагдав.*

САЛТААДАХ салтаагаас шүүрэн авч өргөх.

САЛТААДУУЛАХ салтаадахын үйлдүүлэх хэв.

САЛТАР сэлтэр, хээгүй, эрээгүй, цээргүй; сэлтэр **салтар** хорш..

САЛХАЙ амьтан хэлбэр гахайтай адилхан, толгой нь шар, сүүл нь цагаан нэгэн зүйл гөрөөс.

САЛХАЙЛГАХ салхайхын үйлдүүлэх хэв.

САЛХАЙХ салхгар болох; *залхуу хүрч бие салхайгаад байна.*

САЛХГАНАХ салхгар юмны салхга салхга хөдлөх.

САЛХГАНУУЛАХ салхганахын үйлдүүлэх хэв.

САЛХГАР 1. хувцас хунар элбэгдэж ихэдсэн нь, халхгар; 2. шилжсэн хашин, залхуу, хойрго; 3. шилжсэн хүний нунж дорой, бие султай.

САЛХИ (Н) агаарын урсгал: **хий салхи, салхи шуурга, салхи шороо** хорш.; *урьхан хонгор салхинд уулын мод ганхана* (ардын дуу); **эрүүл салхи** (цэвэр сайхан агаар); **ширүүн салхи** (хүчтэй салхи); **цагаан салхи** (тогтниун зөөлөн салхи); **улаан салхи** (шороон манан хадуулсан салхи); **хар салхи** (маш хүчтэй, хөнөөлтэй салхи); **хуй салхи** (сочмог шороо босгосон эрчтэй салхи); **жихүүн салхи** (их хүйтэн биш шиг мөртөө жиндүү салхи); **халуун салхи** (бүгнэм бүгчим салхи); **хүйтэн салхи** (жихүүцүүлэх жин ихтэй салхи); **урин салхи, урьхан салхи** (зөөлөн тааламжтай салхи); **салхи сөрөх** (салхины эсрэг явах); **салхи дагах** (салхины урсгал дагуу явах); **салхинд тавих** (юмыг агаарт гаргах); **салхинд гарах** (агаар салхинд явах); **салхи гарах** (салхи үүсэх, ихээр салхилах); **салхи орох** (салхи нэвтрэх); **салхи цохих** (салхинд үлээгдэж сэвэгдэх); **салхи авах** (а. ан амьтан салхиар үнэр сэрэх; б. салхи цохих); **салхи анчлах** (усан онгоцны далбаат салхины эсрэг зөрүүлэн өлгөж хөндлөн гулд зорчин явах); **салхи лүвхийх** (халуун салхи салхилах); **салхи шиг хурдан** (маш хурдан); **салхины нь доогуур гаршгүй** (ойртошгүй); ☆ **салхин тээрэм** (салхины хүчээр хөдлөх тээрэм); **салхин хүрд** (салхины хүчээр эргэлдэх хүрд); **салхин сэнс** (салхины хүчээр эргэх сэнс); **салхины ая дагах** (а. салхины урсгалын аяар өөрийн эрхгүй явах; б. цаг үеийн байдлыг харж аль хүчтэйг аядан дагалдаж явах); **салхин цэцэг** (хүний арьсанд туурах нэг зүйл халдварт өвчин); **салхины чигийрэм цэцэг** ургамал (үндсийг шороонд суулгахгүй, сүүдэр газарт өлгөж ус сүршин чийглэж байвал ургаж цэцэглэдэг, мөнх ногоон навчтай, цагаан шаравтархан цэцэгтэй нэг зүйл ургамал).

САЛХИВЧ юманд салхи оруулахаар хийсэн нүх сүв; *салхивч нээх.*

САЛХИГҮЙ тогтниун аятай; *салхигүй өдөр.*

САЛХИДАХ 1. салхинд зүдэх; 2. амьтны салхины эсрэг сөрч явах; *тэмээ салхидаад байна.*

САЛХИДУУЛАХ салхидахын үйлдүүлэх хэв.

САЛХИЙХ маш сулхан, хүч муутай, дорой болох; *бие салхийсэн залхуутай өдөр байна.*

САЛХИЛАХ салхи хөдлөх

САЛХИЛУУЛАХ салхилахын үйлдүүлэх хэв.

САЛЧИН сал удирдан явуулах хүн.

САЛШГҮЙ салахын аргагүй, хагацаж холдож болшгүй; *салшгүй сайн хань нөхөд; салшгүй сайхан амттан жимс.*

САЛЮТ ёслолын буудлага, галын наадам; *салют хийх.*

САМ I 1. үс самнах хэрэгсэл; **сам шүүр** х о р ш.; *сагсгар самбай гэзгэнд сам шүүрийг тааруулсан юм* (дуу); 2. малын хөөврийг самнаж авах хэрэгсэл, самнуур; *хөөврийн сам;* 3. зуух дотор дээр нь гал түлж үнсий нь доош гоожуулах сараалж төмөр; *пийшингийн сам;* ☆ **сам боорцог** (зуурсан гурилыг нимгэлэн хавтгайлж битүү самнан зүсч хоёр этгээдийг бөгтрөн нугалж тосонд чанасан нэг зүйл боов); **сам хорхой** а м ь т а н (зарам загасны нам, сахал урт, хөл олон, хоёр хавчууртай, бнед үе үе хальстай).

САМАЛДАГ хамрын доторхи, угийн мөгөөрсөн сархиаг.

САМАЛДАГЛАХ самалдгийн тус газар дохих, дэлдэх.

САМАР зарим модонд байх дотроо идээтэй, гадуураа ясан хальстай үр жимс; *хушийн самар; самрын яс хаяж үл болно;* **самар томох** (самар цөмөх); **самар цөмөх** (самрын ясан хальсыг шүдээр хагачин доторхи үр цөмийг авч идэх); **самрын цөм** (самрын идээ); **самрын тос** (самрын цөмөөс гаргаж авсан тос); **самрын яс** (самрын хальс); **самрын зулам** (самрын дотоод шар хальс): **самрын боргоцой** (самрын үүрлэсэн хонгорцог); **самрын боргоцог** (самрын боргоцой); **самар сайруулах** (самар цайруулах); **самар цайруулах** (самрыг боргоцойноос нь салгах); **самрын цөмт шообин** (самрын цөм хийж хайрсан нэг зүйл идээ).

САМАРГАХ I самрахад хүрүүлэх, самруулах.

САМАРГАХ II самуурахад хүрүүлэх, самууруулах.

САМАРДАХ юмыг гар савраараа савардах, маажих; *хуухэд самардах; нохой самардах; гарааараа газар самардах.*

САМАРДУУЛАХ самардахын үйлдүүлэх хэв.

САМАРЧ: самарч бялзуухай а м ь т а н ар нуруу этгээд хар, хамар урт, самар иддэг нэгэн зүйл жижигхэн шувуу.

САМАРЧИН самар түүгч хүмүүс.

САМБАА 1. завдаа, сэхээ; *тэр хооронд самбаа алдсангүй;* 2. чөлөө, зав, завдал; *нэг самбаандаа өрөөнд нь оров; самбаа олох.*

САМБААГҮЙ сэхээгүй, завдаагүй золбоо мүутай.

САМБААЛАХ самбаа гаргах, самбаачлах.

САМБААТАЙ завдаатай, сэхээтэй; *самбаатай тулдаа шаварт ойчсонгүй.*

САМБААЧЛАХ 1. бусдын чөлөө завгүй, эзгүй байхад, юмыг эдлэх, ашиглах; 2. чөлөө зав олж үйлдэх.

САМБААЧЛУУЛАХ самбаачлахын үйлдүүлэх хэв.

САМБАГАА самбаа.

САМБАГААГҮЙ ухаа сэхээгүй, самбаагүй золбоо хөдөлгөө муутай.

САМБАГААТАЙ ухаа сэхээ, золбоо хөдөлгөө сайтай.

САМБАГАНАХ 1. сэмбэгнэх; намбаганах самбаганах х о р ш.; 2. саамганах; *их самбаганадаг хүн.*

САМБАГАР намбагар, сэмбэгэр.

САМБАЙ I доод зэргийн муу хадаг; **хадаг самбай** х о р ш.; *сэтэрхий зүүнээс, сэмэрхий самбайнаас* (оньсго худалдахад хэлэх үг).

САМБАЙ II: **сахал самбай** сахал үс.

САМБАР 1. юм бичиж зурахад зориулсан хавтгай ялтас; *самбар дээр шохойгоор бичих; хичээлийн самбар; чулуун самбар,* **сурын самбар** (сур харвахад оноог тэмдэглэх самбар); **үнсэн самбар** (үнс наалдуулж бичих зурахад хэрэглэх зүйл); 2. нимгэн банз; *самбар банз; самбар хаалга;* 3. сайшаах буюу муушаах зэргээр тусгайлан тэмдэглэхэд зориулсан хэрэгсэл; **хүндэт самбар** (хүндтэй хүний зураг зэргийг гаргах самбар); **улаан самбар** (сайшаалын самбар); **хар самбар** (муушаалын самбар).

САМБАРЛАХ самбар болгох.

САМБАРЛУУЛАХ самбарлахын үйлдүүлэх хэв.

САМГАН ахимаг насны эмэгтэй хүн.

САМГАРДАХ давхацсан ажилд сандрах, тэвдэх; *яарч самгардаад юмаа мартжээ; самгардах хэрэггүй, галт тэрэг явах болоогүй байна.*

САМГАРДУУ хялбар самгардан сандардаг, тэвдүү.

САМГАРДУУЛАХ самгардахын үйлдүүлэх хэв.

САМДИ I шашны ёсны бясалгал; *самдид суух.*

САМДИ II а м ь т а н янз байдал биччтэй адилхан болоод хар, өвчүүнээс доош үсгүй.

САМЖ а м ь т а н өнгө шаравтар, сүүл охор төрөлхийн тавтиргүй шогч, бяцхан бич.

САМНАА зузаан дөрвөлжин хэлбэртэй хийж тосонд чанаж болгосон нэгэн зүйл нарийн боов.

САМНАГДАХ самнахын үйлдэгдэх хэв.

САМНАЛГА самнах үйлийн нэр.

САМНАХ 1. самаар ширхгийг засах; *үс самнах; гээзэг самнах;* 2. тусгай самаар самнаж нооллуурыг авах; *ямаа самнах; хөөвөр самнаж авах;* 3. бумбаар хөхүүлэн арьсыг зорчин зүсч, дахин дээрээс нь бумбадан хөхүүлж анагаах; 4. олон зэрэгцсэн ширхэг зураас гаргах; 5. ш и л ж с э н олон хүн зэрэгцэн явж эрэх, хайх; *үүл самнах; модон дотуур самнан явав.*

САМНУУЛАХ 1. самнахын үйлдүүлэх хэв; 2. самнагдах.

САМНУУР малын үс ноос самнах сам.

САМПИН тоо бодох эрхэн тоолуур бүхий тусгай хэрэгсэл, бодох мохлаг ч гэдэг; **сампин цохих** (сампингаар тоо бодох).

САМПИНДАХ сампингаар тоо бодох.

САМПИНДУУЛАХ сампиндахын үйлдүүлэх хэв.

САМРАХ 1. шингэн зүйлийг шанага мэтээр утган авч, дээрээс буцааж асгах; *сүү самрах; цай самрах;* 2. адуу урд хөлөө дээш өргөж цавчих; *хоёр азрага самралцан ноцолдов,* 3. усанд сэлэх; *усанд самрах.*

САМРУУЛАХ самрахын үйлдүүлэх хэв.

САМРАЛЦАХ самрахын үйлдэлцэх хэв, харилцан самрах.

САМСАА хоншоорын хоёр хажуугийн бяцхан хонхор; *хамрын самсаа.*

САМУУН 1. шудрага биш, будлиан хутгасан, үймээн түйвээнтэй; *самуун хулгай; самуун явдал; самуун цаг;* 2. шалиг завхай; садар; *шалиг самуун; садар самуун.*

САМУУРАЛ самуурах үйлийн нэр; *будлиан самуурал* х о р ш.;

САМУУРАХ 1. самуун болох, муу явдалтай болох; *тийнхүү сургуулиа хаяж самууран эхлэв;* 2. самуун дэгдэх, үймээн түйвээн гаргах; *нутагт нь хулгай дээрэм дэгэн самуурч билээ;* 3. ш и л ж с э н завхайрах, садарлах; *ужидлан самуурах;* 4. ш и л ж с э н ухаан оюун үймцэн уймрах, будлиатах; *олон биччийн дотор самуурч хоцров; ухаан самуурах.*

САМУУРУУЛАХ самуурахын үйлдүүлэх хэв, самуурахад хүргүүлэх.

САМХАЙ өмхий: **өмхий самхай** х о р ш.,

САМЦАХ ээдрэх, ороолдох; *утас самцах.*

САМЦУУЛАХ самцахын үйлдүүлэх хэв.

САМЧИХ 1. байн байн самрах; 2. юм юманд оролцох, хүрэлцэх.

САМШААХ самшихад хүргүүлэх, самшуулах.

САМШИГДАЛ самшигдах үйлийн нэр; *самшигдал учруулах; самшигдал болох;* **дутагдал самшигдал** х о р ш.,

САМШИГДАХ самшихын үйлдэгдэх хэв, дэмий үрэгдэх *санхүүг самшигдуулсан ялт эргээд.*

САМШИГДУУЛАХ самшигдахын үйлдүүлэх хэв.

САМШИХ үрэх, идэж завших, ашиглах; *чийгмийн өмчийг самшиж хэрхэвч болохгүй.*

САМШУУ идсэн уусан юмыг боловсруулах зам; *ходоод гэдэсний самшуу.*

САМШУУЛАХ самшихын үйлдүүлэх хэв.

САН I 1. улсын мэдэл, өмчинд холбогдох зүйл; **сан хүү** х о р ш.; *улсын санд оруулах; сангаас хэрэглэх; сангийн морь;* **сангийн аж ахуй** (улсын аж ахуй); **сангийн яам** (улсын мөнгөн хөрөнгө, түүний эргэлт, төсөв, зээлцэг тэргүүтнийг хариуцах яам); 2. аливаа чухаг зүйлийг хуримтлуулсан газар, хөмрөг; *эрдэнийн сан;* **номын сан** (нийтэд хэрэглүүлэхээр ном судрыг хуралдуулан хадгалах газар; *улсын номын сан; хотын номын сан; номын сангийн курс*); **эмийн сан** (а. нийтэд эм худалдах газар; б. мөн чухал эмийг ялган авч хайрцагласан сав; *гэрийн эмийн сан*); **усны сан** (усыг нөөцөлж ашиглах газар, цөөрөм); 3. ш и л ж с э н маш их алдартай, үнэтэй зүйл; *дэлхий*

дахины уран зохиолын санд өөрийнхөө зохиолыг оруулжээ; ардын аман зохиолын баялаг сан.

САН II шашны ёсны ариутгал; *сан тавих.*

САНАА бодол, сэтгэж бий зүйл; **санаа сэтгэл** х о р ш.; *миний санаа бол: урьдаар барилгын нэг хэсгийг барья; санаагаа хэлэх;* **санаа муутай** (муухай санаа агууламтгай; *санаа муут яван хатна, сарьсан баавгай наранд хатна* з ү й р; **муу санаатай** (хорон муухай санаа сэтгэлтэй; *муу санаа бие отно);* **хар санаа** (хөнөөлт муу санаа сэтгэл; *хар санаа хор, хатуу сэтгэл жад);* **цагаан санаа** (сайн сайхан сэтгэл); **сайн санаатай** (сайхан сэтгэлтэй); **санаа сайтай** (хар хоргүй, сайхан сэтгэлтэй); **хорон санаа, хорт санаа** (хорлол хөнөөл бүхий муу санаа; *хорон санаа агуулах; хорт санаа өөрлөх);* **санаа амрах** (сэтгэл тайвшрах); **санаа эргэх** (урвах, няцах); **санаанд орох** (гэнэт санах); **санаанд орохгүй** (ажрахгүй, тоохгүй); **санаа авах, санаа сэрэх** (ямар нэгэн юмнаас сэдэвлэж шинэ санаа төрөх); **санаа орох, санаа төрөх** (шинэ санаа бодол сэрэгдэн орох); **үнэн санаа** (чухам бодол, ёстой бодол, үнэн эрмэлзлэл); **гол санаа** (гол агуулга); **санаа буцах** (бодол зорилтоо буцах, эргэх шантрах, няцах); **санаа сэдэх, санаа үүсгэх** (эхэлж санал онолоо гаргах); **санаанд хүрэх, санаандаа хүрэх** (*бодсон санасан* нь бүтэж биелэх); **санаа тэжээх** (хүний сэтгэлд нийцүүлэн урамшуулах); **санаа тавих** (анхаарал тавих; *санаа тавьж анхаарах хэрэгтэй);* **санаа өртөм** (явдал хэтрүү, уур ихтэй); **санаагаар унах** (бодож санасаар гутрах); **санаагаараа зохиох** (дураараа зохиох); *санаа муу бол заяа муу, самсаа муу бол хамар муу* з ү й р; *сайн хүн санаагаараа, сайвар морь жороогоороо* з ү й р;

☆ **санаа алдах** (шүүрс алдах).

САНААРХАЛ санаархах үйлийн нэр, санаашрал.

САНААРХАХ санаа орхих, хүсч дурлах, цанхаалах; *чи надтай санаархаад байх хэрэг юүн? түүнд санаархахаа боль!*

САНААРХУУЛАХ санаархахын үйлдүүлэх хэв.

САНААТАЙ 1. ямар нэгэн бодолтой, санаа агуулж бий; *та ямар санаатай байна? маргааш явах санаатай байна;* 2. зориуд; **зориуд санаатай** х о р ш.; **санаатайгаар** (зориуд санаа агуулж, голдуу муу санаагаар хийх үйлдэх; *санаатайгаар эвдэх; санаатайгаар мушгих; чи санаатайгаар чингэж байна уу? санаатайгаар хойшлуу гах).*

САНААЧЛАГА 1. санаачлах үйлийн нэр, аливаа шинэ үйл ажиллагааны эхлэлт, эхлэл; *шинэ санаачлага гаргах; шинэ санаачлага, оновчтой саналыг дэмжих хэрэгтэй;* 2. идэвх зүтгэл, оролдлого.

САНААЧЛАГЧ санаачлага гаргагч; *шинийг санаачлагч.*

САНААЧЛАГЧИД санаачлагч олон; *шинийг санаачлагчдын зөвлөлгөөн болов.*

САНААЧЛАЛ санаачлах нь, санаачлага.

САНААЧЛАХ 1. санаа оноо бодож сэдэх бүтээх, аливаа шинэ юмыг эхлэх үүдэх; *ур цэвэрлэх машин санаачлан хийхээр оролдож байв;* 2. үйл ажилд хичээл зүтгэл гаргах.

САНААЧЛУУЛАХ санаачлахын үйлдүүлэх хэв.

САНААШИРХАХ 1. гүн бодолд автагдах; 2. хүсэл төрөх.

САНААШРАЛ санаашрах үйлийн нэр,

САНААШРАХ 1. хүсэл бодол болох, бодлогошрох; *санаашрах зовохын хэрэг алга;* 2. хүсэл төрөх.

САНААШРУУЛАХ санаашрахын үйлдүүлэх хэв.

САНАГАЛЗАХ нэхэж санах, мартахгүй байх; *бороо ихээхэн орж хадлан хадахад саад болж болохыг санагалзах хэрэгтэй.*

САНАГАЛЗУУЛАХ санагалзахын үйлдүүлэх хэв.

САНАГДАХ 1. санахын үйлдэгдэх хэв, санаанд орж ирэх; 2. мартагдахгүй, санаанд байх; *зун орж шумбадаг гол нь санагдав.*

САНАГДАШГҮЙ санаанд оршгүй, бодогдошгүй.

САНАГДУУЛАХ санагдахын үйлдүүлэх хэв.

САНАЛ 1. бодож байгаа зүйл, бодол, бодлого, санаа, хүсэл, эрмэлзлэг; *санал нийлэх; санал нийлсэн нөхөд; санал төрөх; санал гаргах;* **санал оруулах** (ямар нэгэн газарт бодлоо илэрхийлэх); **саналаар нь болгох** (хүссэнээр нь болгох); **саналы нь авах** (юу гэж хүсч байгаагий нь анхаарч мэдэх); **санал алдагдах** (гомдох сэтгэл төрөх, урамгүй болох, дургүй хүрэх); **санал алдах** (гомдох, дургүй хүрэх);

2. олон нийтийн байгууллагын болон төрийн хэрэг явдлыг шийдвэрлэхэд өөрийнхөө бодлогыг илэрхийлэх эрх; *олонхийн саналаар таслах;* **санал хураах** (санал цуглуулах, санал авах; *нууц санал хураах);* **санал хураалт** (санал хураах явц, санал хураах үйлийн нэр); **санал нэгтэй** (нэгэн бодолтой); **санал хуваагдах** (а. эргэлзэх, тээнэгэлзэх, үл шийдвэрлэх, тогтворгүй болох; б. аливаа юмыг шийдвэрлэхэд хүмүүсийн бодол ацдах, хуваагдах).

САНАЛГА аливаа юманд хүрэх сайн санаа; **саналга сайтай** (ухаан сэргэлэн, авхаалжтай); саналга муутай (ухаан дорой).

САНАЛГАГҮЙ ухаан бодол муутай, авхаалжгүй.

САНАЛГАТАЙ ухаан бодлого сайтай, авхаалжтай, авхаалж сайтай.

САНАЛТАЙ санал бүхий; *та ямар саналтай байна? өөр саналтай хүн байна уу?*

САНАМГҮЙ ухаан санаанд ормооргүй.

САНАМЖ 1. сэргээн санах нь, сэргэмж; **санамж сэргэмж** х о р ш.; **2.** сануулга: санамж өгөх.

САНАМЖЛАХ санаа бодол үүсгэх, сануулах.

САНАМЖЛУУЛАХ санамжлахын үйлдүүлэх хэв.

САНАМСАРГҮЙ санаандгүй атал, урьд нь бодоогүй атал; *санамсаргүй явсаар өнөөх хүнтэйгээ уулзав; санамсаргүй хэрэг.*

САНАМСАРЛАХ санан сэрж бодох.

САНАТОРИ сувиллын газар.

САНАХ 1. сэтгэх, бодох; **санах сэрэх, санах сэтгэх, санах бодох** х о р ш.; *санаж байгаа юмаа хэл!* **хар санах** (муу санаа агуулах); **сайн санах** (сайн санаа агуулах); **буруу санах** (хортой санаа агуулах); **муу санах** (хар санах; *чи над битгий муу санаарай!);* **санасан дээр нь** (санасан даруйд нь); **санасандаа хүрэх** (зорилгодоо хүрэх, зорилгоо биелүүлэх); **санах нь сарнаар, явах нь нарнаар** (санасан бодсондоо хүрч чаддаггүй); **их санасан газар есөн хоног хоосон** (их л сайхан гэж бодсон атал тэр нь муу, юу ч үгүй байх); **санаснаас дээр** (үг бодож байснаас илүү, дээр); *өөдлөх өд санах сэрэх хоёр; уруудахад унтах мартах хоёр* (хууч); *санасан бүхэн чинь сэтгэлилэн бүтэх болтугай!* (ерөөлийн үг); 2. нэхэн бодолд орох; *хаа тавьсан бэ? санаач! хэдэнд ирсний нь бид санахгүй байна;* 3. хүсч мөрөөдөх; *гэрээ санах; нутгаа санах; ээжээ санах.*

САНВААР шашны ёсны сахилын үүрэг; *санваар сахих; гэлэнгийн санваар.*

САНВААРТАН шашны ёсны санваар бүхий хүмүүс, сахилтан.

САНГАС I махчин шувууны баас.

САНГАС II 1. толгойн үс маш сэргэг; *сангас үхэр;* 2. азар; *сангас лам.*

САНГАЙХ эмэгтэйчүүдийн үс зүсээ засч янзлаагүй үзэмжгүй харагдах.

САНГАРЦАГ эе эвгүй сэгсийсэн өрвийсөн их үс; *сангарцаг толгой.*

САНГАРЦАГЛАХ үс нь өрвийж сэгсийх.

САНГАСХИЙХ сууж байгаад гэнэт ухасхийн босох, явах.

САНГАХ махчин шувууны баах.

САНД (АН): санд мэнд, сандан мэндэн маш яарч тэвдсэн байдал; *санд мэнд гүйв; санд мэнд босон харайв.*

САНДААЛГАХ сандахад хүргүүлэх, сандуулах.

САНДААХ сандахын үйлдүүлэх хэв; *хүчлага сандаах.*

САНДААЧИХ 1. сандаах; 2. байн байн сандаах.

САНДАЙЛАХ юман дээр хоёр хөлөө унжуулан суух; *сандал дээр сандайлах; модон дээр сандайлж суух.*

САНДАЙЛУУЛАХ сандайлахын үйлдүүлэх хэв.

САНДАЛ хүн суух, түшлэгтэй исэр; **сандал ширээ** х о р ш.; *сандал дээр суух; зөөлөн сандал.*

САНДАРГАХ сандрахын үйлдүүлэх хэв, сандраах.

САНДАРХАЙ 1. сандруу, тэвдүү; 2. сандарсан, сандсан байдалтай.

САНДАХ хэвийн байдал үймрэн хөдлөх; *хүчлага сандах.*

САНДИЛ сандал.

САНДРААХ сандрахын үйлдүүлэх хэв.

САНДРАЛ сандрах үйлийн нэр; *сандралд учрах.*

САНДРАХ бачимдах, тэвдэх; *яаран сандран гарч гүйв; хүндэт зочдыг ирэхийг гэнэт сонсоод ихэд сандрав.*

САНДРУУ тэвдүү, яаруу; *сандруу явах;* **яаруу сандруу** х о р ш..

САНДРУУЛАХ сандрахын үйлдүүлэх хэв.

САНДУУРАХ уйтгарлаж мэндүүрэн тогтворгүй болох; **мэндүүрэх сандуурах** х о р ш..

САНДЧИХ 1. их л тэвдэж сандрах; 2. байн байн сандаах.

САНДЧУУЛАХ сандчихын үйлдүүлэх хэв.

САНЖГАНАХ дүүжлэн ганхах, унжганах, сажилзан хөдлөх; *санжганан хөдлөх.*

САНЖГАНУУЛАХ санжганахын үйлдүүлэх хэв.

САНЖГАР унжгар, унжсан юм; *санжгар зүүлт.*

САНЖИЙЛГАХ санжийхын үйлдүүлэх хэв, санжгар болгох.

САНЖИЙХ санжгар болох, унжийх.

САНЖИЛЗАХ унжин санжин хөдлөх.

САНЖИЛЗУУЛАХ санжилзахын үйлдүүлэх хэв.

САНЖИН: унжин санжин унжганаж санжганаж байгаа зүйл.

САНЖИР: унжир санжир унжсан санжсан юм, унжин санжин.

САНЖИХ унжих, хугарах, хэмхрэн хажуу тийш унжих; **унжих санжих** х о р ш..

САНЖЛАГА эмэгтэйчүүдийн чих ба шанаадаа өлгөж зүүх унжлага чимэг.

САНИТАР эмчлэн сувилах газрыг цэвэрлэх, мөн өвчтөн шархтанд үйлчлэх ажилчин.

САНМИЙ у р г а м а л хоног амуутай адил болоод өнгө харавтар нэгэн зүйл будаа.

САНСАР орчлон; *сансрын далай* (тоост ертөнц); *сансрын хүрд* (шашны ёсны нэгэн зүйл зураг).

САНСКРИД 1. сайтар нийлүүлсэн гэсэн үг; 2. эртний Энэтхэгийн утга зохиолын хэл; *Санскрид хэл.*

САНТИМЕТР метрийг зуу хуваасны нэгтэй тэнцэх уртын хэмжээ; *сантиметрийн шугам; хоёр метр наян сантиметр.*

САНУУЛАГЧ сануулах үйл гүйцэтгэгч.

САНУУЛАХ 1. санахын үйлдүүлэх хэв; 2. бусдын осол бурууг дурдан хэлж өгөх; *энэ удаа чиний бурууг сануулж өгье.*

САНУУЛГА санамж болгон хэлсэн үг; *сануулга болгож хэлэв; сануулга авах.*

САНХАЙЛЦАХ олон хүн, өндөр газарт харагдах.

САНХАЙХ толгойн үсийг арчлахгүй сагсайлгах.

САНХРАХ яарч тэвдсэн учир замдаа тохиолдсон юмыг огт үзэхгүй өнгөрөх.

САНХҮҮ ардын аж ахуйн гүйлгээнд хэрэглэгдэх улсын мөнгөн хэрэглүүр; *санхүү-эдийн засгийн сургууль;* **санхүүгийн ажилтан** (нягтлан бодох зэрэг санхүүгийн ажлыг хийх хүмүүс).

САНЧ сан хадгалагч; *номын санч;* ☆ **санч хэрээ** а м ь т а н (цагаан толгойтой, том биетэй хэрээ).

САНЧИГ эмэгтэйчүүдийн үсний гөрлөөнд ороогүй үлдээсэн сул буюу богино үс: **санчиг тавих** (санчгаа ургуулах).

САНЧИР Бямба гараг, үзэсгэлэнт од ч гэдэг.

САР (АН) I 1. нарны туяанд гэрэлтэж харагдах, тэнгэрийн эрхэс, дэлхийн дагуул; *сартай шөнө; сарны гэрэлд хулгайч дургүй, сайн хүнд муу хүн дургүй* з ү й р; **заримдаг сар** (тал сар); **тэргэл сар** (бүтэн дугуй сар); **сар бүрэг, сар бүрхий** (сарны өнгө бүдэг); **сар хүрээлэх** (сарыг хүрээлж солонго туяа тогтох); **сар хавьслах** (шинэ сар гарах); **сар саруул** (сарны гэрэл тодорхой); 2. хагас дугуй мэт тэмдэг; *тооны дараа сар хийх; саран тамгатай үхэр;* **саран сүх** (тал сарны хэлбэртэй жижиг сүх); 3. бууны онь хараа; 4. мал адгуусны магнай дээрх хэсэгхэн цагаан толбо; *сартай зээрд морь;* 5. жилийг арван хоёр хуваасны нэг болох цаг улирлын хэмжээний нэгж; *гуч хоногтой сар; сарны сайныг саатан хүлээж, өдрийн сайныг өнжин хүлээж, өнөөгийн өдрийг өлзийтэй, сайн өдөр гэсэн юм биз ээ* (ерөөл); **сарын шинэд** (аравнаас урагших

өдөр); **сарын хуучид** (хориноос хойших өдрийг); **сар хуучрах** (сар эцэслэн шахах); **илүү сар** (сарны зурхайн ёсны аль нэг давхардсан сар); **цагаан сар** (билгийн улирлын нэгдүгээр сар); **тэргүүн сар** (билгийн улирлын 1, 4, 7, 10-р сар); **сар их** (гучин өдөр хүрэх сар); **сар бага** (гучин өдөр үл хүрэх сар); **сар тутам** (сар бүр); ☆ **сарны зурхай** (сарны явдлыг баримталж зурах зурхай); **сарны хөвгүүн** (одон); **сарны хир, сарын бэлэг, сарын тэмдэг** (сарын юм); **сарын юм** (эмэгтэйчүүдийн сар бүрт тогтмол үздэг улаан тэмдэг); **сарны боорцог** х у у ч и р с а н (еэвэн); 6. Даваа гараг; *Саран гараг.*

САР II а м ь т а н өнгө боровтор, элэг цайвар, шонхрын намын махчин шувуу.

САР III: **сар сар хийх** зарим юмнаас шажигнах чимээ гарах.

САРААЛАХ эрээлэх, эрээчих; **эрээлэх сараалах** х о р ш..

САРААЛЖ 1. тор, ханын нүд шиг зүйл гаргаж үйлдсэн зүйл; *цонхны сараалж;* 2. зуух пийшингийн гал түлэх газрын дор байх хоор хоорондоо үнс унах зай завсартай саргар төмөр, ширэм; *зуухны сараалж;* 3. х у у ч и р с а н арзгар хэрчлээстэй мод, дээр нь хүнийг нүцгэн өвдгөөр нь сөхөргөн суулгаж хонгоор нь бөөрөнхий мод хийж, хоёр талаас хүн гишгэх нэг зүйл эрүү шүүлтийн хэрэгсэл.

САРААЛЖДАХ х у у ч и р с а н сараалж гэдэг эрүү шүүлт тулгах.

САРААЛЖИН сараалжлан хийсэн юм; *сараалжин цонх; сараалжин хана.*

САРААЛЖЛАХ сараалж хийх, сараалж болгох.

САРААНА у р г а м а л дараалсан шулуун навчтай, хурц улаан цэцэгтэй ургамал, үндэс нь зууван бөгөөд цагаан үндсийг ухаж иднэ, бас зэрлэг төмс, зэрлэг саримсаг ч гэнэ.

САРААНАГ хуухнаг.

САРААЧИХ зурчих, байн байн сараалах, эрээлэх, эрээчих; *харандаагаар сараачих.*

САРААЧУУЛАХ сараачихын үйлдүүлэх хэв.

САРАВГАНАХ 1. саравгар юмны саравга саравга хөдлөх; *ойчсон тугалын хөл саравганаж байна;* 2. ш и л ж с э н энэ тэр юманд өнгөц халдан явах; *чи олон юманд битгий саравганаад бай, нэг л юм сайн сур!*

САРАВГАНУУЛАХ саравганахын үйлдүүлэх хэв.

САРАВГАР арзгар, арзгар, олон салаатай; **аравгар саравгар** х о р ш.; *саравгар мод; саравгар хөлтэй амьтан.*

САРАВЧ 1. мал, гэр мэтийг цас шуурганаас хамгаалах нөмөр бүхий нэгэн талаас **задгай**, дээвэртэй барилга; *дулаан пин саравч барих ажил; малын саравч;* 2. байшингийн дээврийн туургаас илүү гарсан хэсэг; *байшингийн саравчинд өлгөх;* 3. малгайн магнайны **дээд** этгээдэд урагш гарсан хэсэг; *малгайн саравч; саравчтай малгай;* 4. салхи шороогоос **нүдийг** хамгаалж, зүүдэг тор буюу хорго бүхий **нүдний** шил.

САРАВЧЛАХ нүдний дээд этгээдэд **гараар** гэрлийг халхлан харах; *тэртээ уулыг нар өөд саравчлан харав.*

САРАВЧЛУУЛАХ саравчлахын үйлдүүлэх хэв.

САРАЙЛГАХ сарайхын үйлдүүлэх хэв, сарайхад хүргүүлэх.

САРАЙХ саргар болох, сэрийх; *сарайж харагдав;* **сарайх сэрийх** х о р ш..

САРАМГАР нимгэн, саримгар.

САРАМПАЙ 1. нимгэн, сармай; *сарампай банз;* 2. ноорхой, ноорхой; *сарампай эсгий.*

САРВАА даага; *хар алаг гүүний хонгор сарваа.*

САРВААДАХ шинэдэх, тулгамдах.

САРВААДУУЛАХ сарваадахын үйлдүүлэх хэв.

САРВАЙЛГАХ сарвайхын үйлдүүлэх хэв, саравгар болгох.

САРВАЙХ 1. саравгар болох; 2. ш и л ж с э н юмыг авахаар гарыг тэнийлгэн сунгах; *авахаар гараа сарвайтал* ... 3. ш и л ж с э н гар чинэрэн атгаж чадахгүй, тамиргүй болох; *гар нь сарвайн, уургыг алдав;* 4. морь малын чармайн харайлгах; 5. ш и л ж с э н үнэнээс чармайх, мэрийх.

САРВАЛЖ у р г а м а л зэрлэг ургадаг, улаавтархан иштэй, уртлаг дүгрэгхэн бяцхан навчтай нэгэн зүйл ногоо, борлуулж иддэг.

САРВАЛЗАХ саравгар юмны байн байн хөдлөх; *авах гэж гар нь сарвалзав.*

САРВАЛЗУУЛАХ сарвалзахын үйлдүүлэх хэв.

САРВАСХИЙХ 1. саравгар юмны гэнэт хөдлөх; 2. гарын гэнэт хөдлөх; *гар сарвасхийхийн зуур...*

САРГАЙ: саргай цэцэг у р г а м а л *анхилам* үнэртэй нэг зүйл ургамал.

САРГАР арзгар, сэргэр; **саргар сэргэр** х о р ш.; *саргар мод.*

САРДАГ: сардаг тоть а м ь т а н шар толгойтой, ар жигүүр нь ногоон, сүүл нь алаг нэгэн зүйл тоть.

САРЗАЙЛГАХ сарзайхын үйлдүүлэх хэв, сарзгар болгох.

САРЗАЙХ сарзгар болох, арзгар болох.

САРЗГАР хэрзгэр, сэрзгэр, нягт биш; *сарзгар бичиг; сарзгар даавуу.*

САРИГ сарьдаг.

САРИЙ муруй; **муруй сарий** х о р ш.; *сарий хөлтэй.*

САРИЙЛГАХ 1. сарийхын үйлдүүлэх хэв; 2. муухай бичих.

САРИЙХ саригар болох; **муруйх сарийх** х о р ш..

САРИМГАР хэтэрхий нимгэн, хэврэг.

САРИМСАГ у р г а м а л гашуун амт, сүрхий үнэртэй, булцуут ургамал.

САРИНАЛ сарнил.

САРИНАХ сарних.

САРИНУУ сарниу.

САРИУ сарий, муруй.

САРИУЛАХ сарихын үйлдүүлэх хэв.

САРИХ нохой өрөөсөн хойт хөлөө өргөж шээх.

САРЛАГ төв Азид орших урт үстэй, том, хивэгч адгуус.

САРЛАХ 1. зурах, бичих; *бичих ч гэж сарлачихжээ;* 2. маажих, урах; *мигуй нүүр сарлав.*

САРМАГ манжин.

САРМАГЧИН а м ь т а н биеийн бүтцээр хүнд хамгийн дөт болох нэгэн зүйл сүүн тэжээлт адгуус.

САРМАГЧЛАХ 1. сармагчин зан байдал гаргах; 2. сармагчин агнах.

САРМАЙ 1. үсгүй буюу тачир үстэй арьс; *сармай дээл;* 2. ш и л ж с э н ус муутай, халцагай, тожуул, нимгэн халчгар; *сармай болсон дотор; сармай арьс; сармай банз.*

САРМИЙХ саримгар болох.

САРНАГАР хамрын сартгар том нүхтэйгий нь; *сарнагар хамар.*

САРНАЙ: сарнай цэцэг у р г а м а л нэг зүйл саргай.

САРНАЙЛГАХ сарнайхын үйлдүүлэх хэв.

САРНАЙХ сарнагар болох.

САРНИ: сарни шороо шар өнгөтэй нарийн шороо, зуурч өнгө нийлүүлэхэд хэрэглэнэ.

САРНИЛ сарних үйлийн нэр, саринал.

САРНИЛТ сарнисан нь, сарних явц.

САРНИУ 1. саринуу, сарнисан, чигээ алдсан, жишүү; *сарниу сацраг;* 2. санаа харилцан нийс муу.

САРНИУЛ сарниулах зүйл; **аянгын сарниул** (барилга төхөөрөмжийг аянгаас хамгаалах хэрэгсэл, голдуу газартай утсаар холбосон урт төмөр байдаг).

САРНИУЛАХ сарнихын үйлдүүлэх хэв; *дайсныг сарниулан хөөв.*

САРНИХ 1. завхрах, төөрөлдөх, дэмий тэнэж алга болох; *айл олон болж, адуу мал сарних болов; дайсны бутцохигдсон цэргүүд үймж бужигнан зүг зүгт сарнив;* **салж сарних** х о р ш.; 2. чиг алдан жишиж одох; *сарнисан туяа; үүл сарних.*

САРТ 1. сартай мал адгуус; 2. сар шиг, саран тэмдэгтэй: **сарт гэгээвч** (дүгрэг гэгээвч); **сарт хүрэл хөөрөг** (хөгжмийн зэвсэг); **сарт хэнгэрэг** (хөгжмийн зэвсэг); **сарт жад** х у у ч и р с а н (цэргийн зэвсэг).

САРТАЙЛГАХ сартайхын үйлдүүлэх хэв; *хамраа сартайлгах.*

САРТАЙХ сартгар болох.

САРТАЛЗАХ сартгар юмны сартас сартас хөдлөх.

САРТАЛЗУУЛАХ сарталзахын үйлдүүлэх хэв.

САРТАН I сартгар.

САРТАН II хоншоорын хоёр хажуугийн бяцхан дэрэвгэр.

САРТВААХЬ 1. далайн жуулчны тэргүүн; *баян сартваахь;* 2. зам удирдагч.

САРТГА: сартга сартга хийх сартгар юмны үргэлжлэн хөдлөх.

САРТГАНАХ 1. сартгар юмны сартга сартга хөдлөх; 2. хамрын нүх их бага болж хөдлөх; *хурдан хурдан амьсгалахдаа хамар сартганаж байлаа.*

САРТГАНУУЛАХ сартганахын үйлдүүлэх хэв.

САРТГАР хамрын нүх их; *сартгар хамартай.*

САРТУУЛ Монголын нэгэн овгийн нэр.

САРУЙ муруй, хажуу тийш; **муруй саруй** хорш.

САРУЙЛГАХ 1. саруйхын үйлдүүлэх хэв; 2. шилжсэн муу, муухай бичих; *бичиг муухан саруйлгадаг.*

САРУЙХ саруй болох, муруйх.

САРУУЛ 1. гэрэл гэгээтэй, тунгалаг тодорхой; *саруул тасалгаа; сайхнаас салах, саруулд төөрөх* зүйр; 2. зайтай, уудам; *уудам саруул нутгийнхаа уул талын билчээрт* (дуу); 3. шилжсэн давчдах зүйлгүй, уудам, тайван, уужим; *дотор саруул болов;* 4. сэцэн, мэргэн; *саруул ухаан.*

САРУУЛХАН арай саруул, нилээд саруул.

САРХАД архины өөр нэр; *архи нэртэй; ариун чанартай, сархад нэртэй, сайхан бэлэгтэй* (ерөөл); *сархад савнаасаа буздыг дийлнэ хууч.*

САРХАЙЛГАХ сархайхын үйлдүүлэх хэв.

САРХАЙХ сархгар болох, сартайх; *хамар нь сархайх.*

САРХАЛЗАХ сархгар юмны байн байн сархас сархас хөдлөх.

САРХАЛЗУУЛАХ сархалзахын үйлдүүлэх хэв.

САРХГАНАХ сархгар юмны үргэлжлэн сархга сархга хөдлөх.

САРХГАР сартгар.

САРХИА сархиаг; *сархиа ихтэй газраар явахад төвөгтэй.*

САРХИАГ I 1. энхэл тунхал болсон хотгор гүдгэр газар; *уулын бэлийн сархиаг; саахалт айлын хонь нь сархиагаа дагаад билчиж байна* (дуу); 2. олон тооны уранхай, цоорхойтой; *буурын сүмаар сархиаг болгожээ.*

САРХИАГ II ургамал малгайны өнгөн тал нь цоохор нэг зүйл иддэг мөөг.

САРХИАТАХ сархиаг бий болж тогтох.

САРХИЙХ 1. сар сар гэсэн чимээ гарах; 2. шингэн юм гэнэт хүчтэй олгойдон гарах.

САРХИНАГ 1. хивдэг амьтны дөрвөн хэлтэст ходоодны нэг бөгөөд хоёр дахь удаагаа боловсорсон идээ хоол үүнд орно; **сайн сархинаг** (дотроо иржгэр хээ мэт юмтай); **муу сархинаг** (дотроо хуудас мэт салбантай); 2. шилжсэн олон цоорхой, нүх сүв болсон; *сархинаг болтол нь буудаж орхисон байв;* ☆ **зөгийн сархинаг** (зөгийн үүр).

САРЧГАНАХ сарчгар юмны сарчга сарчга хөдлөх.

САРЧГАНУУЛАХ сарчганахын үйлдүүлэх хэв.

САРЧГАР нимгэн хэврэг, саржгар; *сарчгар хальс; цаас шиг сарчгар.*

САРЧИГНАХ шарчигнах.

САРЧИГНУУЛАХ сарчигнахын үйлдүүлэх хэв.

САРЧИЙЛГАХ сарчийхын үйлдүүлэх хэв.

САРЧИЙХ сарчгар болох.

САРЧИЛЗАХ сарчгар юмны байн байн сарчис сарчис хөдлөх.

САРЬДАГ I мөнх цастай уул, уулын хөвчийн оргил өндөр; *сарьдаг өндрийн хормойгоор, сайхан яргуй цэцэглэж байна* (дуу).

САРЬДАГ II тэсвэр муутай хөнгөн долгин; *сарьдаг хүн.*

САРЬС (АН) I нохой, үнэг мэтийн амьтны *хоншоорын арьс; сарьсан хамар;* ☆ **сарьсан баавгай** амьтан (урд хуруудыг холбосон сарьсан далавч бүхий, хулгана мэт бяцхан амьтан).

САРЬС II ямаа, хонины арьсыг боловсруулан хийсэн бэржгэр илгийн зүйл; *ногоон сарьс хавчуулсан хар булигаар гутлаа өмсчээ.*

САРЬСЛАХ 1. сарьс хадаж үйлдэх, сарьсаар бэхлэх, чимэглэх; *гутал сарьслах;* 2. шилжсэн гуранхилан хатах, гуранхилах, гурж эцэх

САРЬСЛУУЛАХ сарьслахын үйлдүүлэх хэв.

САТИН нэгэн зүйл бөс бараа; *хөх сатин дээл өмссөн хүүхэд явж байна.*

САХ шагаа харвах сум, голдуу шагааг нүхэлж тугалга цутган хийнэ.

САХАЙХ 1. сахлаг юмны сагсайх; өрвийх; 2. шувууны үс өдөө сэгсийлгэн авирлах.

САХАЛ I 1. эр хүний уруул, эрүү, шанаанд ургах үс; **сахал үс, сахал самбай** хорш.; *ооч сахал; нахай сахал; сайн сайн гэхлээр сахлаа таван өнгөөр будах* хууч; **сахал тавих** (сахлаа авахгүй, ургуулахаар үлдээх); 2. ургамлын үндэснээс гарсан нарийн салаанууд; *сонгинын сахал; саримсгийн сахал; хүн орхоодойн сахал;* 3. гутал сөөхий мэтэд дэвсэх өвс.

САХАЛ II ургамал 1. уул хээрт бут бутаар ургадаг, өлөн сахалтай адил навчтай болоод арай богино, аливаа өвснөөс эрт хөхөрдөг нэгэн зүйл өвс; 2. зэрлэг гаймуугийн навчтай адил навчтай, хавар эрт ургаж зуны эхэн үеэр гандаж шарладаг нэгэн зүйл өвс.

САХАЛГҮЙ сахал үс байхгүй.

САХАЛДАХ сахлаас нь барих, үгтээх.

САХАЛДУУЛАХ сахалдахын үйлдүүлэх хэв.

САХАЛЛАГ их сахалтай.

САХАЛТ сахал бүхий; **сахалт яраалж** амьтан (мөрөн голд төрдөг, эрээн биетэй, сахалтай нэгэн зүйл загас); **сахалт цохор** амьтан (өнгө ногоон, толгойдоо эвэр мэт туршуултай нэг зүйл хорхой); **сахалт хөх бух** (хөх бухтай адил, хөл хар, хушуу шар, толгой цагаан, үелэн ургасан сүүлтэй, сахал бүхий нэг зүйл жижиг шувуу); **сахалт тоодог** амьтан (эр тоодог).

САХАЛТАЙ сахал бүхий.

САХДАХ сахаар харвах, сах нь хүнддэх.

САХИА сахиул.

САХИГЧ сахих этгээд; *эвийг сахигчид; орон байр сахигчид.*

САХИЛ 1. сахилга; 2. буддын шашны ёсонд; санваар номд орох, сахиж явах тусгай дүрэм, сахилгатай болох; **сахил санваар** хорш.; **сахил алдах** (сахилга алдах); **сахил хүртэх** (шашны ёсонд; лам гэлэн болох, хар хүн лам болох, эхнэр чавганц болох).

САХИЛГА ямар нэгэн хэсэг бүлгийн бүгдийн дагаж журамлавал зохих журам, горим; **сахилга бат** хорш.; *цэргийн сахилга бат; хөдөлмөрийн сахилга бат; сургуулийн сахилга бат;* **сахилга алдах** (сахилгыг гажуудуулах, буруу хэрэг хийх).

САХИЛГАГҮЙ хэв журмыг хайхардаггүй.

САХИЛГАЖИХ сахилгатай болох.

САХИЛГАЖУУЛАХ сахилгажихын үйлдүүлэх хэв.

САХИЛГАТАЙ сахилга бүхий, сахилга сайтай.

САХИЛТАН сахил санваар сахигчид

САХИУЛ сахиж харгалзах үүрэгтэй хүмүүс.

САХИУЛАХ сахихын үйлдүүлэх хэв.

САХИУЛСАН шашны ёсны сахиж харгалзаж байдаг гэж итгэсэн юм; *бурхан сахиулсан; чойжин сахиулсан; номын сахиулсан.*

САХИУС шашны ёсны сахиулахаар биедээ зүүх юм; *сахиус зүүх; өврийн сахиус;* **сахиус даллах** (сүнс дуудах).

САХИХ 1. харгалзах, манах; **гэр сахих** (гэртээ үлдэж, гэр бараагаа харгалзах); **сахин хамгаалах** (байнга байж хамгаалах); **үүд сахих** (үүд харгалзах); 2. дэргэд нь байх; **өвчтөнийг сахих** (дэргэд нь үргэлж байж сувилах); 3. хүлээх, отох; *нухний ам сахих;* **тарвага сахих** (тарваганы гарч ирэхийг хүлээх); **зам сахих** (замын хажууд отон хүлээж байх); 4. шилжсэн хоргодох, холдож чадахгүй байх; *гэрийн мухар сахих;* 5. мөрдөж дагах журамлах; **хэв журам сахих** (нийтийн журам дэглэм дагах); **санваар сахих** (шашны ёсонд: авсан сахилаа ёсчлон дагаж явах); **төлөвийг сахих** (төлөв томоотой байх); **төвийг сахих** (төлөв томоотой, алинд нь ч оролцохгүй байх).

САХЛАГ I амьтан сахалт цохроос арай багахан болоод биедээ үс бүхий хорхой.

САХЛАГ II өтгөн, өндөр, урт ургасан; *сахлаг үс; сахлаг өвс; сахлаг ногоо.*

САХЛАРХУУ 1. сахал ихтэй; 2. сахалтай төстэй.

САХЛАХ сахдах.

САХУЙХ 1. сагсайх, сэгсийх; *үс өрөвлөг нь сахуйх;* 2. зарим шувууны өрөвлөгөө сэгсийлгэн, жигүүрээ дэвэлхийлэн газар маажлах; *тахиа сахуйх.*

САХУУ зарим амьтны эмгэглэж хамраас нь шингэн нус шиг юм гоожих өвчний нэр; *ноҳойн сахуу; адууны сахуу.*

САХУУРАХ сахуутах, сахуу өвчин тусах.

САХУУТАХ сахуурах.

САЦ зэрэг, даруй, чацуу, мэгц, мэгц; *хүрээд сац; ирээд сац.*

САЦАЛ цацал.

САЦАХ *цацах.*

САЦЛАХ I чацуулах, зэрэгцэх.

САЦЛАХ II цацлах.

САЦРАГ цацраг; *сацраг туяа.*

САЦРАХ цацрах.

САЦРУУЛАХ сацрахын үйлдүүлэх хэв, цацруулах.

САЦУУ чацуу, чицуу, чуцуу.

САЦУУР цацуур.

САЦУУХАЙ хэмэрлэг хяруулын өөр нэр.

САЦЧИХ цацчих.

САЯ I мянган мянга, арван бум; *олон сая хүн энх тайвны төлөө тэмцэж байна.*

САЯ II өнгөрөөд удаагүй; *сая ирэв; сая танилцаж байгаа хүн; саянаас уншиж сурч байгаа хүн;* **сая тугаар** (тун саяхан).

САЯВТАР саяхан, төдий л удаагүй; *саявтар хотод ирсэн хүн; саявтар бороо орсон болоттой газар.*

САЯДАА ойрдоо, мөддөө.

САЯТ (АН) сая төгрөгийн хөрөнгөтэй; *саят хамтрал; саят хөрөнгөтөн.*

САЯХАН сая, саявтар, өнгөрөөд удаагүй; *тун саяхан энд байсан; саяхны хэрэг шүү.*

СЕКУНД 1. минутыг 60 хуваасны нэгтэй тэнцүү цагийн хэм; 2. градусыг 360 хуваасны нэгтэй тэнцүү өнцгийн хэмжүүр.

СЕМИНАР 1. дээд сургуульд оюутнууд, багшийн удирдлагаар хэсэг бүлэг салж хийх дадлагын хичээл; *семинарын хичээл;* 2. аливаа мэрэгжилтнийг бэлтгэх, мэрэгжлий нь дээшлүүлэх түр сургууль; *багш нарын семинарт ирэв.*

СИЙГҮҮЛЭХ сийгэхийн үйлдүүлэх хэв.

СИЙГЭХ үүгж нэвт үлээх; *цонхоор салхи сийгэж байв; яндангаар утаа сийгээд болохгүй юм.*

СИЙЛБЭР сийлж хийсэн зүйл; *сийлбэртэй хүрэн зандан ширээ; сийлбэртэй хас чулуун хөөрөг; сийлбэрийн хутга.*

СИЙЛБЭРЛҮҮЛЭХ сийлбэрлэхийн үйлдүүлэх хэв.

СИЙЛБЭРЛЭХ сийлж урлах, сийлэх.

СИЙЛБЭРТ сийлбэртэй, сийлбэр бүхий.

СИЙЛБЭРТЭЙ сийлбэр бүхий.

СИЙЛБЭРЧ (ИН) сийлбэр хийдэг хүн.

СИЙЛГЭХ сийлүүлэх.

СИЙЛМЭЛ сийлж хийсэн, сийлбэрлэсэн *сийлмэл шатар.*

СИЙЛҮҮЛЭХ сийлэхийн үйлдүүлэх хэв.

СИЙЛЭГЧ сийлдэг хүн, сийлбэрч.

СИЙЛЭХ 1. бичиг зураг мэтийг хатуу юман дээр ухаж, цоолж гаргах; *бар сийлэх; хэв сийлэх; модон дээр сийлэх; зэс дээр сийлэх;* 2. хатуу юмыг зорж, ухаж юмны дүрс гаргах; *шатар сийлэх; модоор морь сийлэх;* 3. зүсээн юмыг хутгаар зүсч огтлох; *мах сийлэх* ☆ **ухаан сийлэх** (юманд авхаалж гаргах).

СИЙМГЭР 1. нягт өтгөн бишү, сийрэг; 2. маш нимгэн; *сиймгэр даавуу.*

СИЙМИЙЛГЭХ сиймийхийн үйлдүүлэх хэв.

СИЙМИЙХ сиймгэр болох.

СИЙМХИЙ 1. нягт барилдсан бишү, онгорхой, завсар заагтай, нүх сүвтэй; *сиймхий даавуу;* 2. юмны хоорондын завсар, зайдуу газар; *махны хоорондох сиймхий;* **хавирганы сиймхий** (хавирганы завсар); **шүдний сиймхий** (шүдгүй онгорхой газар); **ойн сиймхий** (ойн сийрэг чөлөө газар); 3. шилжсэн тохиромжтой үе, зай, чөлөө; *сиймхийгий нь олох сиймхийгий нь тааруулах.*

СИЙМХИЙДҮҮЛЭХ сиймхийдэхийн үйлдүүлэх хэв, сиймхийгий нь тааруулан үйлдэх.

СИЙМХИЙДЭХ 1. хэтэрхий сиймхий байх; 2. шилжсэн сиймхийгээрээ тохиолдох, тааралдалгүй өнгөрөх.

СИЙМХИЙЛЭХ сиймхийдүүлэх.

СИЙМХИЙРЭХ сиймхий болох.

СИЙРС (ЭН) дэрс хулсаар сүлжиж хийсэн эд эдлэл; *сийрсэн малгай; сийрсэн дэвсгэр.*

СИЙРҮҮЛГЭХ сийрүүлэхэд хүргүүлэх.

СИЙРҮҮЛЭХ сийрэхийн үйлдүүлэх хэв, сийрэг болгох; **бичиг сийрүүлэх** (цэвэрхэн хуулж бичих): **мах сийрүүлэх** (бүхэл махыг нарийн огтлон өлгөж хатаах).

СИЙРЭГ I тармаг, цөөвтөр, энд тэнд; *энэ аманд айл сийрэг байна; малыг сийрэг билчээрлүүлэх хэрэгтэй.*

СИЙРЭГ II ухаалаг, сэргэлэн бачимдаж сандрахгүй; *тэр гуайн ухаан хичнээн сийрэг сайхан байна вэ; сийрэг ажиллаж байна.*

СИЙРЭГДЭХ хэтэрхий сийрэг болох.

СИЙРЭГЖИХ сийрэг болох; *ажил сийрэгжиж, амьсгал авахтай болж байна.*

СИЙРЭГЖҮҮЛЭХ сийрэгжихийн үйлдүүлэх хэв, сийрэг болгуулах.

СИЙРЭГХЭН нилээд сийрэг.

СИЙРЭГШИХ сийргийн шинжтэй болох.

СИЙРЭГШҮҮЛЭХ сийрэгшихийн үйлдүүлэх хэв.

СИЙРЭХ 1. сийрэг болох, цөөрөх, шингэрэх; *үүл сийрэх; манан сийрэх; үзэсгэлэнд хүн сийрснээс хойш оров;* **хөл сийрэх** (хүн цөөрөх); 2. хатаж эхлэх; *нойтон мах сийрч байна; газар сийрэх;* 3. зай, завсар, чөлөө гарах; *миний ажил явдал одоогоос сийрч байна.*

СИЙХ I сиймхий, сийрэг, зай завсартай болох; *хөгшрөн шүд нь сийж байна;* **гол хоёр нь сийж яваа** (малын хөгширч яваа).

СИЙХ II зорьсондоо хүрэх гэж чармайх, мэрийх.

СИЙХГҮЙ 1. яаж ч магадгүй; *тэр чинь юу ч гэж хэлэхдээ сийхгүй шүү;* 2. мэрийлт чармайлт гаргахгүй.

СИЙЧИХ олонтоо сийлэх, байн байн сийлэх, сэндчих; *хүтээр сийчих; газар сийчих.*

СИЙЧЛҮҮЛЭХ сийчлэхийн үйлдүүлэх хэв.

СИЙЧЛЭХ байн байн сийчих; *газар сийчлэх.*

СИМФОНИ найрал хөгжмөөр тоглох том хэмжээний зохиол; *симфони найрал хөгжим.*

СИНДИКАТ зах зээл дээр ноёрхох, их ашиг олохын тулд байгуулагдсан капиталист үйлдвэрийн газруудын монополист нэгдэл.

СИСТЕМ аливаа үйл явдал, юмны тодорхой горим, тогтолцоо.

СИСТЕМЛЭХ системтэй болгох.

СЛЕСАРЬ төмөр сэлбэг хэрэгсэл үйлдэхүүнийг гараар засварлах, хийх мэрэгжилтэй хүн; *слесарь болох; слесарийн түр сургууль төгсөх.*

СО: со өтөг амьтан өнгө шаравтархан цагаан, толгойн үс бүрхэж ургасан, хүн шиг босч чаддаг нэгэн зүйл баавгай.

СОВ халиу.

СОГОГ 1. эмгэг, гэм; *хөлдөө согог олох; согог суусан мал;* 2. зэм, гэм, өө, буруу; *тийм нэг согогтой хүн ажээ; согогий нь хэлэх юм бол...согог олох:*

СОГОГДОХ хэтэрхий өө сэв эрэх; *та намайг согогдох хэрэг юун?*

СОГОГЛОХ согог эрэх, согог санах; *та битгий согоглож бодоорой.*

СОГОГРОХ согог орох.

СОГОГТОХ согогтой болох.

СОГОО марал, бугын эм нь; *согоо сайхан чихтэй...* (хурдан морьны цолоос); **согоон чих** ургамал (зэрлэг ургадаг, урт навчтай, цагаавтар өнгөтэй, шар сорьстой, амт амтайхан нэгэн зүйл ногоо).

СОГООВОР ургамал нуга, ойн чөлөө, сөөгийн завсар хоорондуургадаг олон настай, үндэслэг ишит, үет ургамал, малын тэжээлд хэрэглэнэ.

СОГООЛИН ургамал шаравтархан өнгөтэй, хурууны өндөг мэт том нэгэн зүйл жимс.

СОГОЦ амьтан далайд оршдог, алтан хацартай адилхан нэгэн зүйл загас.

СОГСГОР сөөсгөр, соосгор; *согсгор үстэй охин.*

СОГСОЙЛГОХ согсойхын үйлдүүлэх хэв.

СОГСОЙХ согсгор болох, өрвийх, үс мэтийн хэсэгхнээр босох, гозойх; *гээзэг нь согсойх.*

СОГТОНГИ согтсон нь; *согтонги байдалтай.*

СОГТООГЧ согтоодог юм; *согтоогч унд.*

СОГТООХ согтоход хүргүүлэх, согтуулах; *согтоох ундаан.*

СОГТОХ 1. охьт ундны зүйлийг ууж ухаан балайрах; *архинд согтох;* 2. ш и л ж с э н олон юманд үймцэж самуурах; *үгэнд согтох.*

СОГТУУ согттол уусан, согтож ухаан балайрсан; *согтуу хүн сохор ухаантай з ү й р;* **согтуу өвс** у р г а м а л (навч нь далбагар, эхүүн үнэр бүхий том цэцэгтэй өвсөрхөг, хорт ургамал).

СОГТУУРАХ 1. согтох, үргэлжлэн архи ууж согтуу явах; *байнга согтуурч явдаг амьтан;* 2. мангуурах, мансуурах.

СОГТУУРУУЛАХ согтуурахын үйлдүүлэх хэв.

СОГТУУРХАХ агсамнах, согтуудаа эрдэх, согтуу байдал гаргах.

СОГШИН: согшин инээх түгшин инээх.

СОД (ОН) I онцгой, тасархай, ижил хосгүй, гайхам сайхан; *сод хүн; сод ухаантан; содон харагдах;* **содон юм** (бусдаас өөр, онцгой юм);

СОД II 1. шувууны гол урт өд; *тасын сод;* 2. сур харвах үргэлж өдтэй сум; *содоор харвадаг харваач.*

СОДЛОХ I сод болох, онцгой болох; *тэдний дотор тэр нь аргагүй л содолж байв.*

СОДЛОХ II 1. содтой болгох; *сум содлох;* 2. *соды нь авах.*

СОДОЛЬ халиар ногоо.

СОЁЛ хүн төрлөхтний үйлдвэр, нийгэмлэг, оюун ухааны талаар гаргасан ололтын цогц; соёл боловсрол, эрдэм **соёл х о р ш.**; *Монголын соёл бол үндэсний хэлбэртэй, хувьсгалын агуулгатай байна; соёлын түүх; эртний Грекийн соёл;* соёлын **довтолгоо** (соёлч боловсон байдлыг эзэмших, эзэмшүүлэх талаар гарсан нийгмийн хөдөлгөөн); **соёлын өв** (дээр үеэс улиран дамжиж ирсэн соёлын уламжлал).

СОЁЛЖИХ соёлтой болох.

СОЁЛЖУУЛАХ соёлжихын үйлдүүлэх хэв, соёлтой болгох.

СОЁЛТ соёлтой, соёл бүхий; *эртний соёлт орон.*

СОЁЛЧ соёлжсон нь; *соёлч орон; соёлч хүн.*

СОЁМБО соёнбо.

СОЁНБО 1. Өндөр гэгээн Занабазар гэгч хүний зохиосон нэгэн зүйл монгол үсэг; *соёнбо үсэг;* 2. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын далбаа дээрх тэмдэг; *соёнбо тэмдэг.*

СОЁНГО амьтныг агталснаас болж судас нь гэмтээд доголох өвчин.

СОЁНГОРОХ соёнго болох.

СОЁНГОТОХ соёнго өвчтэй болох.

СОЁНГОТУУЛАХ соёнготохын үйлдүүлэх хэв.

СОЁО I 1. үүдэн шүд ба арааны хоорондбайдаг шүд; *гахайн соёо; зааны соёо;* **соёо сахал** (дээд уруулд байх хоёр жигүүр нь дээш эргэсэн сахал); **соёо мөс** (гоожсон ус хөрч тогтсон гонзгор мөс); 2. сурын зангилаа, уяаг тайлахад хэрэглэх ооно мэт амьтны эврийн үзүүр бүхий хэсэг; 3. ганс сэтгэх махир төмөр; *гансны соёо;* 4. ш и л ж с э н энд тэнд, оочин цоочин, оёо соёо.

СОЁО II тарьсан үрийн **анх** цухуйж ургах хэсэг; *ногооны соёо нь цухуйж байна.*

СОЁОДОХ 1. соёоноос барих, үгтгээх; *зааныг соёодон барив;* 2. соёогоороо хазах; *намайг халтар нохой соёодоод авав;* 3. өрөөсөлдөх, ижилгүйдэх.

СОЁОДУУЛАХ соёодохын үйлдүүлэх хэв.

СОЁОЛОН адуу, үхэр, хонь ямааны таван настай нь; *соёолон үхэр; соёолон ямаа; хуучин соёолон; шинэ соёолон; их нас соёолон хоёр нэг өдөр давхив;* **хавчиг соёолон** (адууны зургаан настай нь);

СОЁОЛОХ I амьтны соёо шүд ургах.

СОЁОЛОХ II ургамлын сүелэх; *ногоо соёолж байна.*

СОЁОЛУУЛАХ соёолохын үйлдүүлэх хэв.

СОЁОРОХ ноғоо сая цухуйж ургах.

СОЁОХОЙ хоёр настай ооно.

СОЁРХОЛ зөвшөөрөл.

СОЁРХОХ 1. зөвшөөрөл өгөх; **айлдан соёрхоно уу** (хэлж өгнө үү); 2. хайрлах, өгөх; *хэшиг соёрхох.*

СОЁРХУУЛАХ соёрхохын үйлдүүлэх хэв.

СОЁХ өршөөл, эрдмээр хөхүүлэн хөгжүүлэх; *соён сургах; соён гийгүүлэх; соён хүмүжүүлэх.*

СОЙВОН хуучирсан хутагт хувилгаадын шадар бараа бологчдын ахмад тушаал.

СОЙЗ юм зүлгэх цэвэрлэхэд зориулан хийсэн хэрэгсэл; *шүдний сойз; дээлийн сойз.*

СОЙЗДОХ сойзоор зүлгэх, арчих, цэвэрлэх; *хувцсаа сойздох; сойздож цэвэрлэх.*

СОЙЗДУУЛАХ сойздохын үйлдүүлэх хэв.

СОЙЛГО 1. адууны сойх дэл; **сойлго тавих** (сойх тавих); 2. адуу тэмээ мэт эдлэгээний малын бие тэнхлийг засахаар уях уяа; **уяа сойлго** хорш.; **сойлго алдах** (сойх явдал дутах); **сойлго нийлүүлэх** (сойлгыг тохируулах); **сойлго ханах** (сойлго нь таарах).

СОЙЛГОХ сойхын үйлдүүлэх хэв.

СОЙЛГУУЛАХ сойлгохын үйлдүүлэх хэв.

СОЙЛОХ цойлох; *шувуу сойлон нисэх; сум дэгжин сойлох.*

СОЙЛТ I юмыг гэдрэг нь татаж тогтоох хэрэглэл; *замгийн сойлт.*

СОЙЛТ II малын бие тэнхлийг засах засал, сойлго; *сойлты нь тохируулах.*

СОЙР амьтан тахианы намын томоохон шувуу, мах сайн тул ихэд агнана.

СОЙХ 1. гэдрэг нь татаж тогтоох; *сойж уях;* **жолоогоо сойх** (жолоог бүүрэгт нь углаж тогтоох); 2. морь малын бие тэнхлийг засахаар уях, шавхруулах; *чонын гөрөөнд явахаар морь сойж байв;* 3. бага идэх; *гэдсээ сойх;* 4. халуун юмыг хүйтэн юмаар сэвэх, сэвлэх; *халуун тогоогоо хүйтэн усаар сойх хэрэгтэй;* 5. халуун цагт идэшний зүйлийг хүйтэн сэрүүн газар жихүүрүүлэн тавих.

СОЛБИ хоёр тийшээ хэвтээ, эсрэг хэвтээ; *солби бөхтэй тэмээ.*

СОЛБИЛТ солбих үйлийн нэр, солилт.

СОЛБИО солбисон нь; *солбио хоёр чих нь соотон соотон хөдөлж байна.*

СОЛБИОР солбио.

СОЛБИУЛАХ солбихын үйлдүүлэх хэв.

СОЛБИУР сүлжиж хэрэх, нэхэх утас ширхгийг гохдон татах хэрэгсэл; *нэхэх солбиур.*

СОЛБИХ 1. урт хоёр юмны нэг нэгний хажуугаар зөрөх; *хайч солбиж орхижээ; хөлөө солбиж суух; морины чих солбих;* 2. шилжсэн нүдний хараа ээлжлэн тусах; *давхар алаг нүд нь, дамын хүү дээр солбиод байна* (дуунаас); 3. солбиураар хэрэн нэхэх.

СОЛБИЦОЛ солбицох үйлийн нэр; *гэрлийн солбицол.*

СОЛБИЦОЛДОХ солбицохын үйлдүүлэх хэв.

СОЛБИЦОЛДУУЛАХ солбицолдохын үйлдүүлэх хэв.

СОЛБИЦОХ харилцан солбих.

СОЛГО I солонгос; **солго гуа** ургамал (амтайхан гуатай адил болоод шар ногоон хольцсон өнгөтэй нэгэн зүйл гуа); **солго бин** (буудайн гурилд бал хоршиж, тосонд буцалгасан бин); **солго бялуу** (буудайн гурилд бал хоршиж, тосонд буцалгасан нэгэн зүйл боорцог); **солго цаас** (Солонгос улсад хийсэн цаас).

СОЛГО II хэрүүл цуугианд дуртай хүн.

СОЛГОЙ 1. хүний биеийн зүүн талын, буруу талын; **солгой гар** (зүүн гар, буруу гар); **солгой хүн** (солгой гараар баруунаасаа илүү ажилладаг хүн); **солгой тал** (хүний биеийн зүүн тал); 2. нар буруу эргэсэн, эрчилсэн; *солгой эрчтэй;* **солгой ёс** (буруу ёс); **солгой тэгээ** (зүүн этгээд).

СОЛГУУР цавуу жонхуу мэтийг түрхэхэд хэрэглэх зүйл.

СОЛГУУРДАХ солгууpаар түрхэх нялах.

СОЛЖГОР солжир, өрөөсөн, сондгой.

СОЛЖИЙЛГОХ солжийхын үйлдүүлэх хэв, солжгор болгох.

СОЛЖИЙХ солжгор болох, солжир болох, өрөөсөлдөх, сондгойрох,

СОЛЖИР хос буюу ижил байх юмны ижилгүй өрөөсөн; *солжир эвэртэй үнээ.*

СОЛЖИРДОХ өрөөсөлдөх, ижил хосгүйдэх.

СОЛИГ: солиг саармаг цэх шулуун биш, зөрүү; *солиг саармаг үг; солиг саармаг хэрэг.*

СОЛИГДМОЛ өөрчлөгдмөл; *солигдмол үүл; солигдмол эд.*

СОЛИГДОХ солихын үйлдэгдэх хэв, өөрчлөгдөх; *салхины зүг нь солигдов, хур орж магадгүй; ээлж солигдох.*

СОЛИЛДОХ солихын үйлдэлдэх хэв, хутгалдах, самууралдах.

СОЛИЛЦОО солилцох үйлийн нэр; *бараа таваарын солилцоо;* **эдийн солилцоо** (хоол шингэхэд бие махбодид үүсэх процессийн цогц).

СОЛИЛЦОХ салихын үйлдэлцэх хэв, харилцан солих, хамтран солих, халалцах; *номоо солилцон унших; хувцас хунараа солилцох; ээлж халаа солилцох; арилжин солилцох; саналаа солилцох.*

СОЛИЛЦУУЛАХ солилцохын үйлдүүлэх хэв.

СОЛИО I 1. арилжаа; *солио наймаа;* **солио хийх** (солих, арилжих); 2. хутгалдаа: **холио солио** х о р ш . ; **солиогий нь гаргах** (солигдсоныг засах).

СОЛИО II мэдрэлийн өвчин; *солио өвчтэй хүн.*

СОЛИОРОХ солиотой болох, дэмийрэх; *дэмий битгий солиорооД бай.*

СОЛИОРУУЛАХ солиорохын үйлдүүлэх хэв.

СОЛИОТОЙ солио бүхий; *солиотой үг; ухаан солиотой хүн.*

СОЛИР I сөнөсөн өрхсээс тасран гариг хоорондын зайд асар хурдан явж, агаарт сарних буюу газарт унадаг төмөр чулуулгийн цул; *солир унах.*

СОЛИР II сөлөр, солжир.

СОЛИУ зүйгээр биш, зөв биш; **солиу гажуу** х о р ш . ; **ухаан солиу** (ухаан эрүүл биш).

СОЛИУЛАХ солихын үйлдүүлэх хэв.

СОЛИУРАХ дэмийрэх, солиу болох, солиорох.

СОЛИУТАХ солиу байдалтай болох.

СОЛИХ 1. нэгийг өгч нөгөөг оронд нь авах; *хоёул, үзэж байгаа зургаа солъё;* **сольж барих** (өөрийнхийг өгч, бусдынхыг авч хэрэглэх); 2. сэлэх, өөрчлөх, халах; *дээл солих; нутаг бууц солих; ажлы нь солих; муу гардаг үзэг байна, сольж өөрийг авъя;* 3. хутгах, **самуурах; солих холих** х о р ш.; *номын хуудсыг солих.*

СОЛО гоцлол.

СОЛОНГО (Н) I нарны сацраг бороосны ширхэгт нугалрахын улмаас тэнгэрт үзэгдэх олон өнгийн хагас дугуй зурвас; *бороо арилж, солонго татав;* **солонго татах** (солонго гарах); **солонго сарних** (солонго завхрах); **солонго бүдэгрэх** (солонгын өнгө бүдэг болох); **солонгон бүрхэвч** (нүдний бүрхэвчийн өвөр хэсэг нь бөгөөд үүний өнгөөр нүдний өнгийг ялгаварлана).

СОЛОНГО II а м ь т а н хүрнэтэй адилхан болоод бие бяцхан амьтан, төрөл зүйл олон.

СОЛОНГО (Н) III: **солонгон шувуу** а м ь т а н толгой хушуу улаан, бүх бие нь ногоон, гилбэгнэм гоё сайхан чандартай нэгэн зүйл шувуу.

СОЛОНГОЛОХ 1. солонгын өнгө адил болгох; 2. солонготож харагдах; *соёл эрдэнийн соёнбо үсэг солонголсон* (дуунаас).

СОЛОНГОРОХ солонго мэт харагдах, солонго мэт болох.

СОЛОНГОТОХ солонго мэт өнгөтэй харагдах.

СОЛОНГОТУУЛАХ солонготохын үйлдүүлэх хэв.

СОЛОЧ гоцлол хөгжимч, гоцлол дуучин, гоцлол бүжигч.

СОЛЬЦОХ 1. байн байн солих; 2. хэрэг давхцаж хутгалдах, хөндлөн гулд болох.

СОМРОН а м ь т а н хүн дуут задуулай шувуу.

СОМРОНЗ хим, олс зэрэг үргамлын үр, эмнэлэгт хэрэглэнэ.

СОНАТ эгшиглэлт аялгуу.

СОНБАС урамдахад өмсөх бүгын толгой дууриалгаж хийсэн бүр.

СОНГИНО иддэг ногоо, зэрлэг таримал хоёр зүйл, төрөл зүйл олон; *сонгинотой хуурга; сонгиныи толгой; зэрлэг сонгино.*

СОНГОГДОХ сонгохын үйлдэгдэх хэв; *сонгогдох эрхээ эдлэх; хурлын тэргүүлэгчдээд сонгогдох.*

СОНГОГЧ сонгох эрх бүхий этгээд.

СОНГОДОГ 1. тэргүүн, дээд зэргийн, үлгэр жишээ болсон, нийтэд дэвшилт гэж тоогдсон мэдэгдсэн нь; *марксизм-ленинизмийн сон водое зохиолууд; сонгодое бичгийн хэл;* 2. шилдэг сайн; *сонгодог морь; сонгодог хоол.*

СОНГОЛГО сайны нь ялгаж гаргах шилэлт; *сонголго хийх.*

СОНГОЛТ сонгох үйлийн нэр, сонголго **хийх нь; шилэлт сонголт** х о р ш . .

СОНГОМОЛ сонгогдмол, шилэгдмэл юм; *сонгомол эд.*

СОНГОХ 1. сайныг шилэх, хэрэгтэй ашигтайгий нь шилж авах; *олны дотроос сонгож авлаа; ном сонгож авах; мэрэгшил сонгох;* 2. олны саналаар баталж томилох; *даргыг сонгох; улируулан сонгох; сонгох сонгогдох эрх.*

СОНГУУЛАХ 1. сонгохын үйлдүүлэх хэв; 2. сонгогдох, шилэгдэх.

СОНГУУЛЬ депутат, хариуцлагатай албан тушаалтан, байгууллагын гишүүдийг олноороо хэлэлцэж шилэн томилох; *сонгууль хийх; сонгуулийн тойрог; нийт, тэгш, шууд, нууц саналаа өгөх сонгууль; сонгуулийн өмнөх хурал.*

СОНД: сонд бялзуухай а м ь т а н шар хөмсөгт бялзуухайтай адил боловч бие ихээхэн, хөмсөг цайвар, сүүлийн гол урт, хөл шаравтархан бялзуухай.

СОНДГОЙ өрөөсгөл, онцгой; *сондгой тоо, сондгой болох.*

СОНДГОЙДОХ хэтэрхий сондгой болох.

СОНДГОЙРОХ сондгой болох.

СОНДГОЙРУУЛАХ сондгойрохын үйлдүүлэх хэв, сондгой болгох.

СОНДОЙЛГОХ сондойхын үйлдүүлэх хэв.

СОНДОЙХ сондгой болох.

СОНДОР хүзүүнд зүүх чимэг.

СОНДУУЛ дов; дов сондуул х о р ш..

СОНЖГУУР сонжуур.

СОНЖИГДОХ сонжихын үйлдэгдэх хэв; *бусдад сонжигдох хэрэг бүү хий!*

СОНЖИМТГОЙ бусдыг сонжиж сорих заншилтай, сонжооч.

СОНЖИМХОЙ сонжих зантай.

СОНЖИХ голох, тэнсэж шүүмжлэх; **сорих сонжих** х о р ш.. .

СОНЖООЧ сонжих зантай; *муу хүн сонжооч, мухар үхэр сэжээч* з ү й р.

СОНЖУУЛАХ 1. сонжихын үйлдүүлэх хэв; 2. сонжигдох.

СОНЖУУР ичгүүр, гологдох, сонжигдох нь; **ичгүүр сонжуур** х о р ш.; *ичгүүр сонжуургүй амьтан.*

СОНЖУУЧ сонжооч, сонжимтгой.

СОНЖУУШТАЙ голууштай, сонжмоор, сонимоор.

СОНИВЧХОН сониуч.

СОНИН I тухайн үеийн олон нийт, улс төрийн байдалд зориулсан том хуудастай тогтмол хэвлэл; *сонин бичиг; үнэн сонин; ханын сонин; сонины газар; сонины материал;* **сонин сурвалжлагч** (болж бий үйл явдлыг сонинд мэдээлэх хүн).

СОНИН II хачин, жигтэй, гайхмаар; *сонин эдлэл; сонин санаа; сонин яриа; сонин хэрэг;* **сонин сэвүүн** (сонин сайхан); **сонин юм** (сонирхолтой юм; *би өчигдөр нэг сонин юм үзлээ*); **сонин юу байна?** (мэндлэлцэх үг).

СОНИРХОГ 1. сонирхох зантай; 2. сонирхогдмоор.

СОНИРХОГДОХ сонирхохын үйлдэгдэх хэв.

СОНИРХОЛ сонирхох үйлийн нэр; *сонирхол ихтэй; сонирхол татах; сонирхол муутай.*

СОНИРХОЛГҮЙ сонирхол төрөхгүй, сонирхмоор юмгүй.

СОНИРХОЛТОЙ сонирхол дуршил ихтэй; эрхгүй сонирхмоор; *сонирхолтой кино үзэв; сонирхолтой яриатай хүн.*

СОНИРХОХ 1. сонин гэж бахдах, дурлах; *шинэ жүжигчдийг их л сонирхов; сонирхож удтал ярилцав;* 2. гайхах; *сонирхож харах;* 3. ашигтай гэж үзэх, тус дөхөмтэйд тооцох; *бидний сонирхож байгаа асуудал.*

СОНИРХУУ сониуч, сонирхог.

СОНИРХУУЛАХ 1. сонирхохын үйлдүүлэх хэв; 2. сонирхогдох.

СОНИУЧ нэг юманд сонирхож байснаа төд больж дахин өөр зүйлд сонирхох зантай; *сониуч хүн; сониуч зантай.*

СОНИУЧХАН их сониуч.

СОНО амьтан хоёр далавчтай шавьж, авгалдай нь адгуус амьтны бие дотор орж шимийг сорно.

СОНОВТОР дуулганы орой дахь ховол хонгионд хатгах чимгийн зүйл; *дуулганы соновтор.*

СОНОМ дунд зэргийн хэмжээний нэгэн зүйл хадаг; *соном хадаг.*

СОНОМСОР чих сонор, ухаан тодорхой; *сономсор хүн.*

СОНОР I 1. сонсох эрхтэн, чих: **сонорт хүргэх** (сонсгох); **сонорын эрхтэн** (сонсох эрхтэн); 2. сонсохдоо сайн; *сонор чихтэй;* 3. шилжсэн сэргэг, сэрэмжтэй; **сонор сэрэмж** хорш.; *сонор сэрэмжээ дээшлүүлэх; сонор унтдаг хүн.*

СОНОР II гавал тархины хооронд байдаг сүв, бухий бяцхан сул яс.

СОНОРДОХ 1. хэтэрхий сонор байх; 2. сонсдох, сонсох.

СОНОРДУУЛАХ сонордохын үйлдүүлэх хэв, сонсгох, дуулгах, сонорт хүргэх.

СОНОРХОН арай сонор, нилээд сонор.

СОНСГОЛ мэдэгдэх, сонсгох, дуулгах зүйл; *одоо үүрийн даргаас сонсгол хийнэ.*

СОНСГОХ сонсохын үйлдүүлэх хэв, дуулгах мэдэгдэх.

СОНСДОХ сонсогдох, чихэнд сэрэгдэх, дуулдах; *сонсдох газраас ийн хэлрүүн... ийм үг сонсдож байна.*

СОНСОГДОХ сонсохын үйлдэгдэх хэв, дуулдах; *сонин юу сонсогдож байна?*

СОНСОГЧ сонсох этгээд; *дүгүйлангийн сонсогч.*

СОНСОЛ сонсох хир хэмжээ, сонсох нь; **сонсол сайтай** (сонсохдоо сайн).

СОНСОХ дуулах, юмыг сонсох эрхтнээр мэдрэх, сэрэх; *үлгэр сонсож сүүв;* **сонсох эрхтэн** (чих).

СОНСУУЛАХ сонсохын үйлдүүлэх хэв.

СОНЬ дур, сонирхол; *сонь буурах; сонь хүрэх; сонь татах.*

СОНЬХОН арай сонин, нилээд сонин.

СОНЬЧ сониуч.

СООД цагаан өнгөтэй, талст шүлтлэг бодис; *хоолны сооД; сооД хийх.*

СООТГОНОХ соотгор юмны үргэлжлэн хөдлөх; *хоёр чих нь соотгонож харагдав.*

СООТГОНУУЛАХ соотгонохын үйлдүүлэх хэв.

СООТГОР соотон; *соотгор чихтэй.*

СООТОЙЛГОХ соотойхын үйлдүүлэх хэв.

СООТОЙХ соотгор болох.

СООТОЛЗОХ соотгор юмны байн байн хөдлөх.

СООТОЛЗУУЛАХ соотолзохын үйлдүүлэх хэв.

СООТОН сээтэн; соотон чихтэй; *сохор нохой дүйвээнээр, соотон халтар чимээнээр* зүйр.

СООХГОНОХ соохгор юмны үргэлжлэн хөдлөх. *битгий л соохгоноод байгаарай.*

СООХГОР хөөрхөг бардам зан гаргадаг.

СООХОЙЛГОХ соохойхын үйлдүүлэх хэв, соохгор болгох.

СООХОЙХ соохгор болох; *соохойж харагдах.*

СООХОЛЗОХ хөөргөндөх, сагсуурах; сонин *дээрээ соохолзох, сонио буурахаар хооХолзох* зүйр

СОПРАН тунгалаг хоолой.

СОР 1. амьтны үсний ноолуураас дээш гарч ургах урт ширүүн үс; *үсний сор; цагаан сортой; булганы сор;* 2. малд гишгэгдээгүй соргог шимтэй өвс; *өвсний сор; сор сайтай өвс;* 3. шилжсэн юмны сайн чанартай нь; *сор нь л тэр;* **сор хөөх** (юмны сайныг дагаж явах).

СОРВИ шарх, түүхий зэргийн эдгэрсний дараа арьсан дээр үлдэх царам, ором; *шархны сорви; сорви аних; сорви гарах; сорви тогтох.*

СОРВИТОХ сорви тогтох.

СОРВИТУУЛАХ сорвитохын үйлдүүлэх хэв.

СОРВО у р г а м а л хээр, ойт хээрийн бүсэнд ургадаг том ногоон навчтай, үндэслэг иштэй, үет ургамал, тэжээлийн чанар дунд зэрэг.

СОРГОГ 1. ажиг ихтэй, сонор сэрэмжтэй; *соргог байх;* 2. сэргэлэн; **соргог сэргэлэн** х о р ш.. .

СОРГОГЛОХ соргог байдал гаргах.

СОРИГДОХ сорихын үйлдэгдэх хэв.

СОРИЛГО сорих үйлийн нэр, сорилт; *сорилго хийх.*

СОРИЛТ сорилго, сорьсон нь; *сорилтод олигтой барилдаж чадсангүй.*

СОРИУЛАХ 1. сорихын үйлдүүлэх хэв; 2. сориглох.

СОРИХ 1. тэнсэх, турших; *сорьж үзэх; сорио болов уу, сонжоо болов уу?* 2. бөхийг наадамд барилдахын өмнө дасгаж тусгайлан сургуулилах; *бөх сорих.*

СОРЛОХ 1. үсний сорыг зулгааж авах; 2. ш и л ж с э н юмны сайныг сонгон авах.

СОРМОС сормуус.

СОРМУУС нүдний зовхины ирмэг дээгүүр ургах урт үс; *нүдний сормуус.*

СОРОГДОХ сорохын үйлдэгдэх хэв.

СОРОГЧ 1. сордог этгээд; **шим шүүс сорогч** (өөр бие махбодийн бие дээр буюу дотор нь оршиж түүний шим шүүс, цусаар биеэ тэжээгч); **тоос сорогч** (орон сууц, эд хогшлын тоос шороог цэвэрлэх хэрэгсэл); 2. ш и л ж с э н бусдын хөдөлмөрөөр амьдрагч; *бусдын хөдөлмөрийг сорогч танхай этгээд.*

СОРОЛТ сорох үйлийн нэр; *яндангийн сролт.*

СОРОМ 1. тогтвор чиглэлгүй олон санаатай хүн; 2. сохор хүн.

СОРОНЗОН төмөр буюу болд зүйлийг биедээ татаж чадах төмрийн хүдэр буюу болд; *соронзонгоор татуулах; соронзон гажиг;* **соронзон гүр** (соронзны хүдэр); **соронзон талбай** (соронзны татах үйлдэл бүхий талбар); **соронзон туйл** (соронзонгийн төгсгөл эцэс).

СОРОНЗДОГДОХ сороныздохын үйлдэгдэх хэв.

СОРОНЗДОХ сороныздоор татах.

СОРОНЗДУУЛАХ 1. сороныздохын үйлдүүлэх хэв; 2. сороныздогдох.

СОРОХ 1. юмыг ам руугаа хийн хамт татаж оруулах; *тамхи сорох;* 2. шингэн юмыг хоолой гуурс мэт рүү татан оруулах; *гуурсаар сорох; заан хушуугаараа ус сорч авав; хамраараа ус сорох; цус сордог хачиг хувалж;* 3. хөхөх, татах; *тавьсан бумба арьсыг улаан болтол сорчээ;* 4. ш и л ж с э н мөлжих; *сорон мөлжих.*

СОРС I сэмжээр ороож шарсан элэг.

СОРС II таана, хөмүүл зэргийг аарцтай хольж хатаасан хатаамал; *сорстой хоол; сорстой тэжээл.*

СОРСЛОХ 1. элэг сэмжээр сорс хийх; 2. таана, хөмүүл зэргийг аарцтай хольж хатаах; 3. ш и л ж с э н ихэд зовоох, тарчилгах.

СОРСЛОХ II ноосыг эсгийн зулхайд хэрэглэхээр бэлтгэн хэсэг, хэсэг зулж хуйлах.

СОРСЛУУЛАХ сорслохын үйлдүүлэх хэв.

СОРСОН зүрийн үстэйгээ арьс.

СОРТГОНОХ сортгор юмны үргэлжлэн хөдлөх.

СОРТГОР сэртгэр, соохгор.

СОРТОЙЛГОХ сортойхын үйлдүүлэх хэв.

СОРТОЙХ сортгор болох.

СОРТОЛЗОХ сортгор юмны байн байн хөдлөх, сэртэлзэх.

СОРТОЛЗУУЛАХ сортолзохын үйлдүүлэх хэв.

СОРТОО цог, хий морь, жавхлан, заль, авхаалж; *сортоотой эр; сортоотой хүүхэд.*

СОРТООГҮЙ хий морь, золбоо, авхаалж муутай.

СОРТООЛОХ сортоо гаргах.

СОРТООТОЙ сортоо сайтай, хий морьтой, золбоотой, жавхаатай, авхаалжтай ,зальтай.

СОРУУЛ 1. тамхи татахад аманд зуух тусгай хэрэгсэл; *чулуун соруултай ганс; янжуурын соруул;* 2. сорж татах хэрэгсэл; *соруул бумба.*

СОРУУЛАХ 1. сорохын үйлдүүлэх хэв; *ус сорууулах;* 2. сорогдох.

СОРУУЛДАХ сорууулаар хөхүүлэх, татах.

СОРЬС сонгино, мангина, таана, хөмүүл, гогод зэргийн ногооны үр.

СОРЬЦ үнэт металлын орсон хувь; *хэдэн сорьцын алт вэ?*

СОС: сос цэцэг у р г а м а л богинохон иштэй, ац салаа үлэмж, шовхгор навчтай, салааны үзүүрт бяцхан цэцэг цэцэглэнэ, сайхан үнэртэй нэгэн зүйл ургамал.

СОХ 1. сохортол; 2. бүр, огт, оргүй; **сох дутах** (шууд, оромгүй дутах).

СОХЛОГДОХ сохлохын үйлдэгдэх хэв.

СОХЛОХ 1. сохор болгох; **нуухы нь авах гээд нүдий нь сохлох** (аливаа юмыг сайжруулах гээд улам дордоох); 2. тэг зэрэг юм бичих зурахад бэх бааж битүүрэх; 3. баллах.

СОХЛУУЛАХ 1. сохлохын үйлдүүлэх хэв; 2. сохлогдох.

СОХОЙЛГОХ сохойхын үйлдүүлэх хэв, сохойход хүргүүлэх.

СОХОЙХ 1. сохор болюх, сохор юм шиг болох; 2. цөмрөн хонхойж орох; *хадаасны тав сойчихжээ;* 3. гэрлийн бүдэг болох; *энэ муу чийдэн сохойгоод юм харагдахгүй байна.*

СОХОЛЗОХ 1. сохор мэт байдал гаргах; 2. сүүмэлзэх.

СОХОЛЗУУЛАХ сохолзохын үйлдүүлэх хэв.

СОХОР 1. нүд харахгүй; *сохор хүн; таг сохор; сохор үхэрт худаг бүү үзүүл, согтуу хүнд архи бүү үзүүл* з үй р; 2. ш и л ж с э н учир утгыг эс мэдэх, учир нь эс мэдэгдэх; **сохор балай, мухар сохор** х о р ш.; *аль ч учир нь мэдэгдэхгүй мухар сохор юм хэлэв;* **сохор номин** а м ь т а н (шавьж идэгчийн бүлгийн, газар дор амьдрагч, сүүн тэжээлт амьтан).

СОХОРДОХ сохрын учир тохиромжгүй болох.

СОХРОХ 1. сохор болох; *нүд сохрох; сохорсон биш завших* з үй р 2. цөмрөн хонхойх, далд орох; *хадаас сохрох; шигтээ нь сохрох.*

СОХРУУЛАХ сохрохын үйлдүүлэх хэв, сохор болгох.

СОХЧИХ байн байн сохлох.

СОХЧУУЛАХ сохчихын үйлдүүлэх хэв.

СОЦИАЛ-ДЕМОКРАТ 1. анхандаа олон улсын ажилчны хөдөлгөөн дэх улс төрийн чиглэл байсан бөгөөд хожим нь капитализмын түшиг тулгуур болж, ажилчин ангийн хувьсгалт хөдөлгөөний эсрэг жижиг хөрөнгөтний оппортунист урсгал болжээ; 2. социал-демократ намын гишүүн.

СОЦИАЛИЗМ нийгэм журам; *социализмын материал техникийн бааз байгуулах; социализмыг байгуулах.*

СОЦИАЛИСТ 1. социализмын ёс суртахууныг баримтлагч; *социалист хөдөлмөрийн төлөө бригад; социалист ёсоор ажиллаж амьдарч сурах; социалист орнууд;* 2. социалист намын гишүүн; *зүүн социалист; баруун социалист.*

СОЧИЛ сочих үйлийн нэр.

СОЧИХ цочих, хирдхийх.

СОЧООХ сочиход хүргүүлэх.

СОЧУУЛАХ сочихын үйлдүүлэх хэв.

СӨГ I: сөг өлөн у р г а м а л нэг зүйл өлөн.

СӨГ II: сөг сөг тэмээг хэвтүүлэхэд хэрэглэх аялга.

СӨГДӨЛ сөгдөх үйлийн нэр.

СӨГДӨӨХ сөгтгөх.

СӨГДӨХ 1. сөхрөх, өвдөг дээрээ суух; *сөгдөж суух;* 2. ш и л ж с э н маш их ядрах; *өнөөдөр сөгдөтлөө ажил хийв;* 3. х у у ч и р с а н өвдөг дээрээ сууж хүндлэх, мөргөх; *сөгдөн мөргөх.*

СӨГДҮҮЛЭХ 1. сөгдөхийн үйлдүүлэх хэв; 2. ш и л ж с э н буулгаж авах, дагуулж авах, оруулж авах, гартаа атгах; *бүрмөсөн сөгдүүлэв.*

СӨГЛӨХ 1. сөг сөг гэж дуудан тэмээ хэвтүүлэх; 2. хэвтээ тэмээг сөг сөг гэж дуудан босгохгүй байх.

СӨГЛҮҮЛЭХ сөглөхийн үйлдүүлэх хэв.

СӨГНӨХ найр хурим хийхэд айраг архийг том саванд хийж тавих; *айраг сөгнөх; үүрт сөгнөж үргэлж найрлаж байхын ерөөлийг өргөн дэвшүүлье* (ерөөлийн үг).

СӨГНҮҮЛЭХ сөгнөхийн үйлдүүлэх хэв.

СӨГӨӨ чадвар; *сөгөө тасрах; сөгөө орох; сөгөө барагдах; явах сөгөө алга.*

СӨГТГӨХ сөгдөхийн үйлдүүлэх хэв, сөгдөхөд хүргүүлэх.

СӨД I у р г а м а л иш өндөр, жижиг бөөрөнхий хүрэн толгойтой, гүзээлзгэнийн навч мэт навчтай, ихэнх төрлийн мал иднэ, навчий нь хатааж цай хийдэг, эмнэлэгт чухал хэрэгтэй ургамал.

СӨД II сэцэн ухаант хүн.

СӨДГИЙ зожиг, гажууд зан байдалтай.

СӨДГӨР 1. сөрдгөр дөрдгөр, бяцхан дордойсон; 2. ш и л ж с э н нийц нийлэмжгүй, ааль зан нь хувирсан хүн.

СӨДИЙХ сөдгөр болох.

СӨДЛӨГ I балчиг шаврыг тойрох зам.

СӨДЛӨГ II өдлөг; **өдлөг сөдлөг** х о р ш.

СӨДӨГНӨХ сөдгөр юмны үргэлжлэн хөдлөх.

СӨДӨЛЗӨХ сөдгөр юмны байн байн хөдлөх.

СӨДРӨГ бэлбэрхий туурайн заагт яр гардаг адууны нэгэн зүйл халдварт тахал өвчин.

СӨДРӨГТӨХ сөдрөг өвчин тусах.

СӨЛ I намар гандалгүй үлдсэн ногоо; *ногооны сөл; сөл тасрах; сөл дагаж нуух;* **насны залуу ногооны сөлтэйд** (чадалтай, залуу байх цагт). •

СӨЛ II I. у р г а м а л балчиг газарт бут бутаар ургадаг, олныг адил иштэй, мөнх харганын навчтай адил болоод нарийн, нимгэн навчтай нэгэн зүйл ногоо; 2. у р г а м а л хадын харгай ургасан газар зэллэж чулуунд наалдан ургадаг, янз байдал дээрхтэй адил болоод богино нам, боролсон үзэмтэй адил үртэй нэгэн зүйл өвс.

СӨЛГӨР сөлөр.

СӨЛЖИР солжир.

СӨЛИЙЛГӨХ сөлийхийн үйлдүүлэх хэв.

СӨЛИЙХ 1. сөлөр болох; 2. өлийх.

СӨЛЛӨХ 1. сөл суух, сөлтэй болох; 2. сөл дагуулах; *малаа сөллөж билчээрлүүлэх.*

СӨЛЛҮҮЛЭХ сөллөхийн үйлдүүлэх хэв.

СӨЛӨГНӨХ үргэлжлэн сөлөлзөх байдал.

СӨЛӨЛЗӨХ сөлөр нүдээр харах, өлөлзөх, долилзох.

СӨЛӨЛЗҮҮЛЭХ сөлөлзөхийн үйлдүүлэх хэв.

СӨЛӨР нүдний харц зөрүү; *сөлөр нүдтэй.*

СӨЛӨРДҮҮ арай сөлөр, баахан сөлөр.

СӨМС тариа, ногооны шөл; *цагаан будааны сөмс; байцааны сөмс.*

СӨН I найр хурим хийхэд том саванд хийж тавьсан айраг архи; **сөн түших** (айргийг аяга саванд хийж түгээх).

СӨН II цөн I.

СӨНДЛӨГӨ гол горхийг хөндлөн гарах гарам газар.

СӨНДЛӨХ гол горхийг хөндлөн огтолж гарах.

СӨНДЛҮҮЛЭХ сөндлөхийн үйлдүүлэх хэв.

СӨНӨД Монголын нэгэн аймгийн овгийн нэр.

СӨНӨЛ сөнөх үйлийн нэр, мөхөл.

СӨНӨӨГЧ сөнөөдөг юм; *сөнөөгч онгоц; сөнөөгч этгээд; гал сөнөөгч.*

СӨНӨӨХ сөнөхийн үйлдүүлэх хэв, сөнөх мөхөхөд хүргүүлэх.

СӨНӨХ мөхөх, үхэх, үгүй болох; *ардын дайсан сөнөтүгэй! сөнөх үйлтэн; сөнөж устах;* **сөнөсөн галт уул** (нэгэнт дэлбэрч одоо дэлбэрэхгүй болсон галт уул).

СӨНЧИН сөнг түших хүн. •

СӨӨГ I бутлан ургасан ургамал; *сөөг сөөгөөр ургасан байдаг.*

СӨӨГ II: **сөөг сөг** тэмээг хэвтүүлэхэд өгүүлэх аялга.

СӨӨЛГӨХ сөөхийн үйлдүүлэх хэв.

СӨӨЛЖИЙХ сөөлжихийн үйлдүүлэх хэв, сөөлжиртөх.

СӨӨЛЖИР солжир, өрөөсөн, ижил биш.

СӨӨЛЖИХ 1. сөөлжир, сөлжир болох; 2. сэлгэцэн сүлжих; *өрөө тасалгаагаар сөөлжих хэрэггүй.*

СӨӨЛЖҮҮ сөөлжир, сөлжир.

СӨӨЛЖҮҮЛЭХ сөөлжихийн үйлдүүлэх хэв, сөөлжүү болгох, зөрүүлэх.

СӨӨМ нэг хоёрдугаар хоёр хуруур сунгаж хэмжсэн хэмжээ: үзүүр сөөм ч гэдэг; **мухар сөөм** (хоёрдугаар хурууны үзүүрийг хоёрдугаар үеэр нь нугалж, эрхий хуруур тэнийлгэсний хоорондох хэмжээ).

СӨӨМЛӨХ сөөмөөр хэмжих.

СӨӨНГӨ хоолой чаргуу болж, дуу бүдэх дорой болсон нь; *сөөнгө хоолойгоор хашгирав.*

СӨӨНГӨДҮҮ арай сөөнгө, нилээд сөөнгө.

СӨӨНГӨРӨХ сөөнгө болох.

СӨӨНГӨТӨХ сөөнгө байдалтай болох; *сөөнгөтсөн дуу сонсдов.*

СӨӨНГӨТҮҮЛЭХ сөөнгөтөхийн үйлдүүлэх хэв.

СӨӨРГӨЛӨХ сөрөн явах, сөөргөө явах.

СӨӨРГӨӨ эргээд, буцаад; *өөдөө сөөргөө явах; маргааш сөөргөө явна.*

СӨӨХ дуу хоолой цэвэр биш, бүдэг, бүдүүвтэр, сөөнгө чаргуу болох; *хоолой сөөх.*

СӨӨХИЙ элдсэн арьсаар хийсэн бойтог; *сөөхий гутал.*

СӨР туургагүй саравчин халх.

СӨРГӨӨЛДӨХ сөргөхийн үйлдэлдэх хэв; *та хоёр битгий сөргөөлдөөд байгаарай.*

СӨРГӨӨХ сөргөхийн үйлдүүлэх хэв; *үг сөргөөх.*

СӨРГӨХ сөрөх, эсэргүүцэх; *салхи сөргөх; үг сөргөх; үг сөргөөвөл хэрүүл болдог, үүл сөрвөл бороо болдог* з ү й р.

СӨРГӨЦӨЛДӨХ сөргөхийн үйлдэлцэх хэв.

СӨРГӨЦӨЛДҮҮЛЭХ сөргөцөлдөхийн үйлдүүлэх хэв.

СӨРГӨЦӨХ сөргөхийн үйлдэлцэх хэв, эсэргүүцэлдэх.

СӨРГҮҮ 1. эергүүгийн эсрэг утга, эсэргүү, дагуу биш; **сөргүү үс** (аягүй шорвог үс); 2. эе нийцгүй, уцаар; *сөргүү зантай хүн.*

СӨРГҮҮЛЭХ сөргөхийн үйлдүүлэх хэв.

СӨРДГӨР дордгор.

СӨРЛӨГ биеийн тамирын тэмцээн; **сөрлөгийн талбай** (биеийн тамирын тэмцээн явуулах талбай).

СӨРЛӨХ сөр хийх, саравч барих.

СӨРЛҮҮЛЭХ сөрлөхийн үйлдүүлэх хэв.

СӨРӨГ юмны эеэр үгүй, дагуу нийцүү биш, эсрэг.

СӨРӨХ 1. ус, салхи зэргийн урсгалын өөдөөс зүсэн явах; *урсгал сөрөх; салхи сөрөх;* 2. ширхгийн дагуу биш, түүний эсрэг болох; ☆ **зэтэр сөрөх** (хумсны орчин дахь арьс ховхорч, сэтрэх); 3. зөрчих, эсэргүүцэх.

СӨРС зөрүүд зантай; *сөрс хүн.*

СӨРҮҮЛЭХ сөрөхийн үйлдүүлэх хэв.

СӨРЧ зүйгүй, зөрүүд.

СӨС 1. элэгнээс гарах гашуун шар ногоон шингэн зүйл; 2. мөн сөс бүхий цулцан; *баавгайн сөс; сөс үрэвсэх;* **сөсний гэр** (сөсний сав); **сөс их** (зүрх зориг сайтай, айдаггүй); **сөс хэмхрэх** (машид айх, үхтэлээ айх); **сөстэй** (хөөрхөг дээрэнгүй).

СӨСЛӨХ 1. сөснөөс нь авах; 2. сөс нь их болох; 3. зуйрч дайлах.

СӨСТӨХ сөс өвчтэй болох.

СӨХ хунгар, хөрлөсөн цас; *сөх цасанд сөхөртлөө явав.*

СӨХӨГДӨХ сөхөхийн үйлдэгдэх хэв; **хэрэг сөхөгдөх** (дарагдсан хэрэг гарч ирэх).

СӨХӨГНӨХ бялдуучилж үргэлжлэн **сөхрөх,** бөхгөнөх, долдгонох.

СӨХӨЛЗӨХ байн байн сөхгөнөх, сөхрөх.

СӨХӨӨЛ сөхөөх үйлийн нэр, хяхал, мохоол.

СӨХӨӨЛГӨХ сөхөөхийн үйлдүүлэх хэв.

СӨХӨӨХ 1. буруушаан хяхаж мохоох; 2. цэхрүүлэх.

СӨХӨРГӨХ сөхрөхөд хүргүүлэх, сөхрүүлэх.

СӨХӨХ 1. унжуулсан юмыг өөд нь болгох, шуух; *хаяа сөхөх; үүд сөхөх; хормой сөхөх; малгай сөхөх; сүүлээ сөхсөн нохой;* 2. юмны хавхаг, таглаа зэргийг өөд нь болгох буюу онгойлгох, *нээх; авдрын хавхаг сөхөх; хавтас-*

тай номоо сөхөж үзэв; нүдээ сөхөж харах; 3. дарагдсан хэргийг гаргах; *хэрэг сөхөх; сөхөн мэдүүлэх; сөхөн байцаах.*

СӨХРӨХ бохирох, сөгдөх; *сөхөрч суух; өвдөг сөхрөх; ажил сөхөртлөө хийв.*

СӨХРҮҮЛЭХ сөхрөхийн үйлдүүлэх хэв.

СӨХҮҮЛЭХ сөхөхийн үйлдүүлэх хэв.

СӨХҮҮР сөхдөг юм; *малгайн сөхүүр; сөхүүр мод.*

СПАРТАКИАД биеийн тамирын төрөл бүрийн хэлбэрээр олон нийтийг хамарсан ураддаан тэмцээн; *улсын анхдугаар спартакиад.*

СПИДОМЕТР автомашин болон моторт дугуйг хэдий хол, хэдий түргэн явж байгааг заах хэрэгсэл, хэмжүүр.

СПИРТ чихэр, цардуул, буудай зэргээс нэрж авсан маш халуун чанартай шингэн зүйл; *спирт найруулах;* **ариутгах спирт** (аливаа юм ариутгахад хэрэглэх тусгай найрлага бүхий спирт.

СПОРТ хүний бие махбодыг чийрэгжүүлэхийн тулд хийх биеийн тамирын дасгал; *морин спорт; дугуйн спорт.*

СПОРТОЧ спорт эрхлэгч, спортоор ороддогч.

СТАНДАРТ тогтмол янз, нэгэн хэв.

СТАНЦ 1. замын зогсоол; *төмөр замын станц; нэг станцаас нөгөө станц хүртэл нилээд удаан явав;* 2. зарим албан газар, эрдэм шинжилгээний байгууллагын нэр; *мал аж ахуйн машин станц; цахилгаан станц; цаг уурын станц; туршлага станц.*

СТЕРЕОМЕТРИ нэгэн хавтгай дээр байгаа бус биеийг судлах хэмжихүй ухааны нэгэн хэсэг.

СТРАТЕГ 1. дайн байлдааныг удирдан явуулах арга ухаан; 2. шилжсэн нийгэм, улс төрийн тэмцэл явуулах арга ухаан.

СТРАТЕГИЧ жанжин, стратегийн талаар гүн бат мэдлэгтэй хүн.

СТРИХНИН нэг зүйлийн хүчтэй хор, эмнэлэгт хэрэглэнэ.

СУВ хүч нэмэгдүүлэх үг; *сув сул.*

СУВАГ ус урсах хиймэл буюу ерийн тогтсон нарийвтар мөр, шуудуу; **суваг гуу, суваг шуудуу** хорш.; *суваг малтах; усны суваг.*

СУВАГЛАХ суваг болгох, суваг татах.

СУВАГРАХ суваг гарах, суваг болох.

СУВАГТАХ суваг бий болох, суваг тогтох.

СУВАЙ мал гөрөөсний боосохгүй жил өнжсөн нь; *сувай үнээ; сувай гүү.*

СУВАЙЛАХ малын сувайгий нь ялгаж тусгаарлах; *хонь сувайлах; үхэр сувайлах.*

СУВАЙРАХ сувай болох; *нэг мал сувайрахад нэг тоо хорогдоно.*

СУВАЙРУУЛАХ сувайрахын үйлдүүлэх хэв, сувай болгох.

СУВД нялцгай биетний бие дотор тогтох цагаан буюу шарангуй өнгөтэй жижиг мөхлөг, үнэт чимгийн зүйлд тооцогдоно; *алт мөнгө, шүр сувд; сувдтай алтан эмээг.*

СУВДАГ ховдог, шунахай; **ховдог; сувдаг, сувдаг шунахай** хорш..

СУВДАГЛАХ сувдаг болох, сувдаг зан гаргах.

СУВДАГРАХ сувдаглах.

СУВДАГРАХАХ сувдаг зан гаргах; *ихээхэн сувдаграхвал муу хэрэг болно.*

СУВДАГТАХ сувдаг зан гаргах, сувдаглах.

СУВДЛАХ цагаан цэцэг өвчний туурах.

СУВДЛИГ сугд мэт, сувд хэлбэртэй; **сувдлиг мод** ургамал (майлстай адил маягтай, сувд мэт навчтай мод); **сувдлиг** ургамал (цагаан цэцэгтэй, сувд мэт хүйстэй, хонгорцоглон ургах, хавар цэцэглэдэг цэцэг); **сувдлиг чигийрэм цэцэг** ургамал (өнгө хүрэн, цоморлог нь сувд мэт болоод цэцэглэсэн хойно нэг түүдүү болдог, үнэр маш их нэгэн зүйл цэцэг).

СУВДЛУУЛАХ сувдлахын үйлдүүлэх хэв.

СУВИЛАГДАХ сувилахын үйлдэгдэх хэв, сувилуулах.

СУВИЛАГЧ өвчтөнийг арчлан сувилах; *сувилагч эмэгтэйн тэтгэмжээр...*

СУВИЛАЛ сувилах үйлийн нэр; *сувилал сайтай бол бас ч гайгүй;* **сувиллын газар** (өвчтөн, бие дорой хүнийг асран сувилах га-

зар); **сувиллын гуанз** (өвчтөнийг сувилах тусгай хоол өгөх газар).

СУВИЛАХ арчлах, тордох; хүүхэд, өвчтэй, бие дорой хүнийг өргөх, сахих; *өвчтөнийг сувилж байв;* ☆ **их зэрэг сувилах** (бодоо өвчин хүртэх).

СУВИЛГАА өвчтөн буюу бие дорой хүнийг сувилах, өргөх, арчлах арчлагаа, тордлого; *сувилгаа сайтай; сайн сувилгаа хэрэгтэй.*

СУВИЛУУЛАХ 1. сувилахын үйлдүүлэх хэв; 2. сувилагдах.

СУВРАА цуваа, цувраа; *суврaа чулуу; суврaа толгой.*

СУВРАГА шашны ёсны дурсгалын шүтээн.

СУВРАГАЛАХ суврага дотор агуулах.

СУВРАХ суврaа болох, цуврах.

СУВС I шимийн архи нэрэхэд эцэст нь авсан амт муутай архи; **сувс архи** (усавхи архи).

СУВС II хүзүүний чимэг.

СУВСЛАХ сувс болгох, сувс авах.

СУВСРАХ сувс болох.

СУВЪЕКТ ухамсартай бөгөөд үйл ажиллагаат хүн амьтан.

СУВЬДАГ сувдаг; *хоолонд сувьдаг.*

СУВЬДАГДАХ хэтэрхий сувьдаг болох.

СУВЬДАГЛАХ сувьдаг зан гаргах.

СУВЬДАГЛУУЛАХ сувьдаглахын үйлдүүлэх хэв.

СУВЬДАГРАХ сувьдаг болох.

СУВЬДАГТАХ сувьдаг байдал гаргах.

СУГА Г 1. мөрний үеийн доод этгээдийн хонхор; *сугандаа хавчуулах; суганы булчирхай сочих; суганы хонхор;* **суга таяг** (сугад тулж явах таяг); 2. дээл цамц зэрэг хувцасны мөрний доод этгээдэд байх газар; *дээлийн суга ханзрах;* 3. мал гөрөөсний хааны дотоод завсар; 4. уулын хажуугийн хуудас завсар; *Богд уулын баруун зүүн сугаар дүүрэн айл бий;* 5. суман онгоцны хавирга, ёроолын уулзрын газар; *онгоцны суга.*

СУГА II сугартал нь, сугарч гартал; *суга татах; суга цохих; суга үсрэх.*

СУГАВЧ сугын халхлавч; *хуягийн сугавч.*

СУГАВЧЛАХ юмыг сугандаа хавчуулах; суувчлах; *бичгийн саваа сугавчлан явав.*

СУГАВЧЛУУЛАХ сугавчлахын үйлдүүлэх хэв, суувчлуулах.

СУГАДАЛЦАХ сугадахын үйлдэлцэх хэв, бие биеийн сугаар гарыг оруулан хөтлөлцөх; *олуулаа сугадалцан дуулалдаж явжээ.*

СУГАДАХ насжисан буюу эмгэглэсэн хүн зэргийг суганаас түшиж тулах; *моринд сугадаж мордуулав.*

СУГАДУУЛАХ сугадахын үйлдүүлэх хэв.

СУГАЛАА сугалах тоо дугаарт тохируулан эд юм ба мөнгийг хонжих хонжлого; *сугалаа сугалах; сугалаанаас хонжсон зүйл; улсын хонжворт сугалаа.*

СУГАЛАХ I 1. ямар нэгэн уртавтар юмыг юман дотроос гаргах; *сэлэм сугалах; шувууны өдийг сугалав;* 2. олон бөөмийн дотроос оноож авах; *соды нь сугалж орхив;* 3. сугалааны бичигт цаас буюу дугаарыг авах; *сугалаа сугалах.*

СУГАЛАХ II дээл хувцасны сугыг битүүлэн оёх; *дээл сугалах.*

СУГАЛДРАГАЛАХ дээлийн өрөөсөн ханцуйнаас гараа сугалж гаргах; *халуунд сугалдрагалан явав.*

СУГАЛДРАГАН сугалдрагалсан; *ярахдаа сугалдраган гарч гүйв.*

СУГАЛУУЛАХ сугалахын үйлдүүлэх хэв.

СУГАЛУУР юмыг сугалах хэрэгсэл.

СУГАР Баасан гараг. • **СУГАРАХ** 1. голдуу ямар нэгэн уртавтар юм, юман дотроос гарах; *хутга хуйгаасаа сугарчээ;* 2. шилжсэн олон бөөн юмны дотроос ганцаар тасрах; *сугаран гарах; сугарч хоцрох.*

СУГАЦАЛДАХ сугадалцах.

СУГАЧИХ 1. олныг сугалах, байн байн сугалах; 2. гэнэт нэгмөсөн сугарах; *сугачаад унасныг мэдсэнгүй.*

СУГАЧУУЛАХ сугачихын үйлдүүлэх хэв.

СУГДЛАХ өндөр гоолиг болох, харагдах, *сугдалсан сайхан мод.*

СУГСРАХ дээш өргөж доош хүчтэй дугтрах; *мориноос ойчин муужирсан хүнийг хурдан шүүрэн авч хэдэн удаа сугсрав.*

СУГСРУУЛАХ сугсрахын үйлдүүлэх хэв.

СУГУА у р г а м а л ойт болон хээрийн бүсэнд ургадаг, навч гонзгойвтор, өвлийн цагт тэсвэргүй, бог малд сайн тэжээл болно.

СУДАГ нарийн жалга, суваг.

СУДАЙ үхрийн омруу.

СУДАЛ I 1. судас; *бөөрний судал;* 2. мэдрэлийн сэлтэр; *мэдрэлийн судал;* ☆ **хий судал** (мэдрэл).

СУДАЛ II зурвас, ширхэг, хээ; *судалтай даавуу; чулууны судал;* **навчны судал** (навчны суваг, ширхэгт судас мэт зурвасууд); **тэнгэрийн судал** (тэнгэрийн оёдол); **газрын судал** (ашигт малтмалын тогтцын үе, зурвас).

СУДАЛГАХ судлахад хүрүүлэх, судлуулах.

СУДАЛТАХ судалтай болох; *судалтаж харагдав.*

СУДАР 1. ном, бичиг, түүх, шашдир; **ном судар, судар шашдир, түүх судар, бичиг судар** х о р ш.; 2. үддэггүй урт хөндлөнгөөр дэвтэрлэсэн ном, зохиол; *ширээ дээрээ нэг судар задлан тавьжээ;* **удам судар** (угсаа удам; *удам судры нь дуудах; удам судры нь мэдэх);* **нутаг судар** (газар нутаг).

СУДАРЧЛАХ ном бичгийг судрын маягтай хийх.

СУДАС бие махбодын дотор шингэн зүйл гүйх гуурсан эрхтэн; *цусны судас;* **судас барих** (судас барьж цохилты нь мэдэх); **судас барих, судас үзэх** (судасны цохилтыг барьж шинжлэх.

СУДЛААГҮЙ судалж үзээгүй, судлагаа хийгээгүй.

СУДЛААХ судлуулах.

СУДЛАГАА судлах үйлийн нэр; *судлагаа явуулах хэрэгтэй; ямар ч судлагаагүй.*

СУДЛАГДАХ судлахын үйлдэгдэх хэв.

СУДЛАГДАХУУН судлагдах юм.

СУДЛАГЧ 1. эрдмийн зэрэг хамгаалахаар өрдэм шинжилгээний байгууллага буюу дээд сургуульд судлагаа хийж суралцаж байгаа хүн, аспирант; 2. судалж бий хүн.

СУДЛАЛ шинжлэл, судлагаа; *шувууны судлал; газрын судлал; үгийн гарлын судлал.*

СУДЛАЛЧ судлах мэрэгжлийн хүн; *тахлын судлалч; амьтан судлалч.*

СУДЛАХ 1. хянаж боловсруулах, хянаж шалгах; *ийм асуудлыг судалж байна;* 2. сураглах, ажиглах, турших замаар учир шалтганыг олж мэдэх; *сурч судлах; ажиглаж судлах; туршиж судлах.*

СУДЛАХУУН судлах юм; **археологийн судлахуун** (булш, хөшөө, дурсгал зэрэг).

СУДЛУУЛАХ 1. судлахын үйлдүүлэх хэв; 2. судлагдах.

СУЙЛАГДАХ суйлахын үйлдэгдэх хэв.

СУЙЛАХ 1. юм руу гарыг холоос лав шургуулах; *заваг өөд суйлж тэмтрэв; авдар руу суйлж үзлээ; өөр суйлах;* **карман суйлах** (хулгай хийх); 2. өрөөсөн гараар эсэргүүцлийн хөлийг шүүрэн авах, бөхийн мэх; *суйлж унагаах.*

СУЙЛУУЛАХ 1. суйлахын үйлдүүлэх хэв; 2. суйлагдах.

СУЙТАЛЗАХ хазвалзах, мижилзэх, бага шиг доголох.

СУЙТАН а м ь т а н янз гахайтай адил, соёотой нэг зүйл амьтан.

СУЙТГАНАХ хазганах, мэжигнэх, доголох.

СУЙХ у р г а м а л том өдлөг навчтай, их өндөр ургадаг нэг зүйл шарилж, навчаар нь улавч хийж болно; **суйхан чулуу** (суйхын навчтай адил хөхөөхөн өнгөтэй нэг зүйл чулуу).

СУЛ чангын өсрэг утга; 1. уяагүй, бэхлээгүй, задгай, цоож түгжээгүй; *аргамжсан морь сул явж байна; ачаан дээр сул тавьсан юм; үүдээ сул хаях;* 2. хоосон, хөндий, дотроо юмгүй *сул хувин; сул авдар; сул байр;* 3. хүн унаагүй, ачаа ачаагүй; *сул морь хөтөлж явна;* 4. хэрэглэгдээгүй, эдлэгдээгүй; *сул тэрэг; цаагуур чинь сул үзэг байна;* 5. ажилгүй, энгийн, зүгээр; *ажилгүй сул сууж байна;* 6. аяархан, нам, дорой, чадал муутай; **сул дуугарах** (дорой хоолойгоор эсвэл дургүй дуугарах); **сул биетэй** (ядуу, тэнхээ муутай); 7. барагтай, муу; *сул сурлагатай сурагч; одны ам сул бол*

жээ; 8. амтгүй, усавхи; **сул гарсан архи** (усавхи амттай, тогооны архи); **давс нь сул** (давс нь хэтэрхий бага): **сул шороо** (дагтаршиж хатуураагүй зөөлөн шороо); **сул өгөх** (хэтэрхий хямд өгөх); **сул авах** (хэтэрхий хямд авах); **сул цалин** (ажил хийхгүйгээр авах тэтгэмжийн цалин); **сул тал** (үйл ажлын алдаа дутагдалтай газар); **сул орох** (а. үнэ өртөгүйгээр орлого болох; б. юманд холхи уужим багтах); **сул зогсох** (ажил хөдөлмөргүйгээр цаг нөгчөөх); **сул үг** (а. биеэ даасан утагүй, өгүүлбэрт үгийн өмнө хойно орж утгыг илрүүлэх үгсийн ай; б. дэмий чалчаа яриа хэлэлцээ); **дэл сул** (нарийн нямбай биш байдалтай): **гар султай** (харамлаж чаддаггүй); **ам султай** (задгай амтай, чалчаа); **сул газар** (чөлөөтэй газар, тариалаагүй газар); **сул сайд** (төрийн сайд, яамгүй сайд).

СУЛАЛТАР баахан сул, арай сул.

СУЛБАГАР 1. амт чанар муутай, сулдгар, улбагар; *сулбагар гарсан архи;* 2. чадал тэнхэл муутай, дорой; *сулбагар биетэй охин.*

СУЛБАЙЛГАХ сулбайхын үйлдүүлэх хэв.

СУЛБАЙХ сулбагар болох.

СУЛДАЙХ тэнхэл алдарч бие сулбайх, ядрах; *бие сулдайх.*

СУЛДАХ хэтэрхий сул болох; *уяа нь сулджээ; давс нь сулдах.*

СУЛДГАР сулбагар, улбагар.

СУЛДУУЛАХ сулдахын үйлдүүлэх хэв.

СУЛЛАГДАХ суллахын үйлдэгдэх хэв; *гяндангаас суллагдах; өршөөлөөр суллагдах.*

СУЛЛАХ 1. сул болгох; 2. хоослох, дотор нь юмгүй болгох; *өрөө суллах.*

СУЛЛУУЛАХ суллахын үйлдүүлэх хэв.

СУЛРАЛТ сулрах үйлийн нэр.

СУЛРАХ 1. алдуулах, алдуурах, сул болох; *нохой сулраад явж байна;* 2. чанга биш болох; *татлага суларчээ;* 3. хоосон, дотроо юмгүй болох; *аяга сулрав;* 4. амт чанар буурах, муудах; *архины амт сулрах;* 5. шилжсэн сайн хэлэхгүй болох, муу хэлэх; *нийтийн ам суларсан байна.*

СУЛРУУЛАЛГҮЙ сулруулж болохгүй, сул болгохгүй.

СУЛРУУЛАХ сулрахын үйлдүүлэх хэв.

СУЛТАХ улам сул болох.

СУЛТГАЛ султгах үйлийн нэр.

СУЛТГАХ султахын үйлдүүлэх хэв, сул болгох; *шороог султгах.*

СУЛТГУУЛАХ султгахын үйлдүүлэх хэв, сул болгуулах.

СУЛХАН 1. нилээд сул; 2. муу, муухан; *сулхан бичээч; сулхан зохиолч.*

СУЛЬ ургамал том үндэслэг иштэй, ширүүвтэр бөгөөд цайвар ногоон навчтай, түрүү өтгөн голдуу элсэнд ургадаг ургамал, ялангуяа өвөл цагт малын сайн тэжээл болно.

СУЛЬДАА ядран доройтох, тамирдах нь; *биений сульдаа ердөө гарахгүй байна.*

СУЛЬДААХ сульдахад хүрүүлэх, сульдуулах.

СУЛЬДАХ туйлдаж ядрах, тамирдах, доройтох.

СУЛЬДУУЛАХ сульдахын үйлдүүлэх хэв.

СУЛЬФАТ хүхрийн давс бүхий олон зүйлийн юмны ерөнхий нэр.

СУМ I 1. бууд хийж буудах төмөрлөг буюу хорголжоор хийсэн, шовгор эсвэл мухар үзүүртэй бяцхан зүйл; *винтовын сум туссан газар; цахиур бууны сум; сумтай буу;* 2. мөн тиймэрхүү төмөрлөгийг галт бортгод хийсэн нь; *их бууны сум; сумны хонгио; сумны шарх; сумны агуулах; үрлэн сум* (ангийн бууд хийх бууддаг жижиг тугалган үрлүүд); **зэрлэг сум** (онох цэгээ алдсан тэнүүл сум); **сум тоолох** (харвах, буудахад сум алдалгүй онох); **аянгын сум, тэнгэрийн сум** (аянга буусан газраас олддог эртний хүмүүсийн хүрэл төмөрлөг эдлэл); **тэнэсэн сум тархинд** (аливаа үйл явдал юмны санамсаргүй онох тохиолдох); **сумаа харваад нумаа нуух** (аливаа хэргийг хийгээд ул мөрөө баллах); **сумны овд** (зэв сум дүрэхэд зориулан саадгийн амсарт арьс эсгийгээр зааглан хийсэн нүх); 3. сур ба ан гөрөөс харвах намхан харвуул; *нумны сум;* 4. шагаа харвах харвуул; *шагааны сум;* 5. шагаа шүүрэхэд дээш хаяж тосон шүүрэх шүүрэг; *шүүргийн сум;* 6. зүг чиг заасан зураас буюу зурвас тэмдэг; *зураг дээр сумаар заах; сум зааж тэмдэглэх хэрэгтэй.*

СУМ II засаг захиргаа, газар нутгийн томоохон нэгж; *нэг сумын ардууд; сумын захиргаа; сум-нэгдлийн дарга; сумын харьяат; сум-нэгдлийн нутаг.*

СУМ III: **дээлийн сум** дээлийн гадаад энгэрийн суганаас дооших шулуун зах; *сумыг эмжсэн эмэгтэй хүний дээл.*

СУМ IV: **чөдрийн сум** чөдрийн билчир уулзраас хойших урт хэсэг; *чөдрийн сум нь богиноджээ.*

СУМ V: **тэрэгний сум** тэрэгний арлын хоёр гуяны хөндлөвчөөс урагших хэсэг.

СУМ VI: **анжисны сум** анжисны бөхийн нүхэнд шургуулан хийсэн мод.

СУМ (АН) VII у р г а м а л мод, гоёмсог эдлэл хогшил хийдэг, халуун оронд ургах мод, хүрэн өнгөтэй; *суман мод; суман ташуур.*

СУМАН I ердийн батальонд багтах цэргийн анги *нэг суман цэрэг; суман дарга; морьт суман; сумангийн байлдагч; сумангийн түгээгч.*

СУМАН II х у у ч и р с а н холд зориулан тавьсан өртөө; *өртөө суман; салбар суман; навч суман; дамжлага суман; суман өртөө;* **суман газар** (хол ойрын хэмжээ нь барагцаалбал 20—25 км. орчим газар); ☆ **суман могой** а м ь т а н (маш хурдан харваи үсэрч явдаг нэгэн зүйл могой); **суман онгоц** (бүхэл модыг ухаж хийсэн *бяцхан онгоц*): **суман цэцэг** у р г а м а л (салаа иш нарийн уян, хайлсны навчтай адил навчтай, үнэр ихтэй, өнгө шар цагаан хоёр зүйл байдаг); **суман төмөр** (юмны бүслүүрт чимэглэл болгон торгож хадсан шулуун төмөр; *хутганы хуйны сум*).

СУМДАХ 1. шагааг заавал сумаар харвах; *шагаа сумдах;* 2. шагаа харвах харвуулын сум хүндэх.

СУМЛАХ бууд сум хийх; *буу сумлах.*

СУМЛУУЛАХ сумлахын үйлдүүлэх хэв.

СУМЬЯА Даваа гараг, саран гараг.

СУНААХ 1. сунахад хүрүүлэх, сунагар болгох; 2. сунгах.

СУНАГАР 1. өндөр гуалаг; *сунагар биетэй хүүхэн;* 2. урт нарийхан; *сунагар уурга; сунагар гээж.*

СУНАЙЛГАХ сунайхын үйлдүүлэх хэв, сунагар болгох.

СУНАЙХ сунагар болох.

СУНАЛ юмны жийгнэж сунах нь; хэмжээндээ хүртэл сунасан нь.

СУНАМАЛ I сунасан юм.

СУНАМАЛ II аливаа юмны атирсангүй, сунжирсангүй хэмдээ байх нь.

СУНАХ 1. татагдан урт өргөн болох; *резин мэт агших сунах; эр хүн өсдөг, эсгий сунадаг з ү й р;* 2. уртаашаа байх, биеийн уртаар хэвтэх; үхсэн могой сунаж хэвтэв; **сунаж мөргөх** (шашны ёсонд: бүх биеэр газар хэвтэж мөргөх); 3. ш и л ж с э н хол харайн давхих, чавхдах; *хээр алаг морь чадлаараа сунаж, улаан үнэг хирээрээ сунаж байв;* 4. унжих; *дээлийн ташаа нь сунажээ.*

СУНГАА хурдны морийг уяхад тарлахаас хол газар уралдуулах нь; *сунгаанд давхисан морь.*

СУНГАЛ сунгах нь.

СУНГАХ 1. сунахын үйлдүүлэх хэв, юмыг татаж урт их болгох; *арьс сунгах; резин сунгах; эвхмэл шатыг сунгах; гараа сунгах;* 2. хурдны морь уяхад тарлахаас хол газар сургуулилан уралдуулах; *морь сунгах;* 3. цаг хугацааг урт болгох; *хугацаа сунгах; хоног сунгах.*

СУНГУУ 1. нилээд хол, зайтайхан; *сунгуу өртөө; сунгуу газар;* 2. арай удаан, **аажим**; *сунгуу хугацаа.*

СУНГУУДАХ хэтэрхий сунгуу болох.

СУНГУУЛАХ сунгахын үйлдүүлэх хэв, сунгуу болгох.

СУНГУУРАХ сунгуу болох.

СУНГУУТАЙ улмаар сунгуу болох.

СУНД: сунд бялзуухай а м ь т а н шар-хөмсөгт бялзуухайн нам, бие томоохон, цайвар шар хөмсөгтэй, хөл нь шаравтархан, сүүлийн гол нь урт нэгэн зүйл шувуу.

СУНДАГ резин.

СУНДАЛДАХ сундлах.

СУНДЛАХ 1. унаатай хүний хойно нь унах, сундалдах; *морин дээр сундлах; дугуй дээр сундлах;* 2. юмны араас давхарлаж байх; *сундалсан гэр; хонжоочийн хойгуур хоёр хүн сундлах;* ☆ **сундлан байлдах** х у у ч и р с а н (нэхэн байлдах).

СУНДЛУУЛАХ сундлахын үйлдүүлэх хэв.

СУНДУЙ: ундуй сундуй эмх замбараагүй; *тэднийх нүүх гэж хамаг юмаа ундуй сундуй болгочихсон байв.*

СУНДУУ I өргөс; өргөс сундуу х о р ш..

СУНДУУ II у р г а м а л чавганы модтой адил болоод арай богино, салаад нь зүү мэт өргөстэй нэгэн зүйл мод.

СУНДУУЛИГ: **сундуулиг цэцэг** у р г а м а л ишиндээ сундуутай, шар өнгийн бяцхан цэцэгтэй, улаан үртэй нэгэн зүйл ургамал.

СУНДУУТ сундуутай; **сундуут хайлс** у р г а м а л (навч нь хайлстай адил, сундуутай, модны өнгө шар, мах судал нарийн хатуу нэгэн зүйл мод).

СУНДУУТАЙ сундуу бүхий.

СУНЖИХ 1. удаашрах, удаан болох; *ажил хэрэг сунжиж хоцрох нь;* 2. дам хэлэлцсэн үг анхны байдлаас хувиран нэмэгдэх; *үг яриа сунжвал юунд ч хүргэж мэднэ.*

СУНЖРАХ 1. удаан болох, унжрах; 2. үе аглага болох, садан төрлийн холбоо холдох; *төрөл сунжрах;* 3. дам хэлэлцсэн зүйл нэмэгдэн өөрчлөгдсөөр уул байсантайгаа тохирохгүй утгатай болох; *үг сунжрах; сунжирч сунжирч сураг тасрав.*

СУНЖРУУЛАХ сунжрахын үйлдүүлэх хэв, удаашруулах.

СУНЖУУ сунжих үйлийн нэр; *сунжуу яриа; сунжуу ажил.*

СУНЖУУЛАХ сунжихын үйлдүүлэх хэв.

СУНИАЛГАХ суниахын үйлдүүлэх хэв, суниахад хүргүүлэх.

СУНИАХ 1. бие мөч удтал нэгэн байранд байж чилэхэд биеэ жийгүүлэн сунгаж чилээгий нь гаргах; *би өглөө босохын хамт заавал суниаж заншсан юм;* 2. дүүжин, савлуур зэрэг биеийн тамирын хэрэгслээс барьж гарынхаа хүчинд биеэ дээш өргөх; *савлуурт суниах.*

СУНЧИН хүний чинээ чадлыг зааж бас амжлахад хэрэглэх үг; *надтай тэмцэх сунчин байна уу? үүнийг авах сунчин чамд байхгүй; бие суларч, сунчин тасраад байна.*

СУНЧИНДАХ туйлдах, ядрах, сунчин тасрах.

СУПЕРФОСФАТ фосфортой найруулсан химийн бордоо.

СУР (АН) 1. шир арьсыг урт зүсч элдсэн нь; *суран жолоо; дан суран ноот; сур элдэх; сураар баглах; суран татлага; суран бүс;* 2. нарийн зүссэн сураар сүлжиж хийсэн хонгио буюу бөмбөг, өрж харвана; *сур харвах.*

СУРАГ дам сонсдох мэдээ, чимээ; *сураг чимээ;* **сураг ажиг, сураг танаг** х о р ш.; *сургий нь сонсох; арван наймтай Жунай айсуй явах сурагтай* (дуу); *алдсан тэмээний сураг гарчээ; сураг танаггүй алга болжээ.*

СУРАГГҮЙ огт сураг чимээгүй; *сураггүй алга болжээ.*

СУРАГЛАХ энд тэндээс асуух, лавлах, сурвалжлах; *асууж сураглаж явсаар аянчны нэгэн майханд хүрэв.*

СУРАГЛУУЛАХ сураглахын үйлдүүлэх хэв.

СУРАГЧ сургуульд суралцаж байгаа хүн; *дунд сургуулийн сурагч; сурагчдын зөвлөлгөөн.*

СУРАЛ сурах үйлийн нэр, сураглах, сурвалжлах; *эрлийг сурлаар олдог, эрдмийг хичээлээр сурдаг* х у у ч..

СУРАЛЦАХ 1. сурахын үйлдэлцэх хэв; 2. сургуульд сурах, хичээллэх; *миний хүү их сургуульд суралцаж байгаа.*

СУРАЛЦУУЛАХ суралцахын үйлдүүлэх хэв.

СУРАМГАЙ дадамгай, сурч дадсан, сурмаг; *сурамгай хүн чадамгай* з ү й р; *сурамгай болох; хэлэмгий байна, сурамгай байх;* **сурамгай доголон** (тогтсон доголон гэм).

СУРАХ I 1. ямар нэгэн мэдлэг, заншил мэтийг эзэмших, мэддэг чаддаг болох; *эрдэм ном сурах; шатар сурах; тэсвэртэй байж сурах; сурсан нь далай, сураагүй нь балай з ү й р;* **сурах бичиг** (аливаа юманд сургах бичиг; *хэл зүйн сурах бичиг; сурах бичиг зохиох*); 2. занших, дадах; *гараа өргөж сурах; алга ташиж сурах; тамхи татаж сурах; муу зан сурах; ирсэн замаараа сурсан дуугаа дуулах.*

СУРАХ II сураглах, сурвалжлах, асуух; *чамайг нэг хүн сурч байна билээ.*

СУРВАЛЖ 1. юмны уг, үндэс, ёзоор; *шүдний сурвалж; ургамлын сурвалж;* 2. язгуур, угсаа; 3. эх үүсгэл; *сурвалж бичиг; энэ хэргийн сурвалжий нь олох явдал чухал байна;* 4. ш и л ж с э н сураг, чимээ; *сурвалж нь гарахгүй нь бололтой.*

СУРВАЛЖИТ 1. сурвалж бүхий, сурвалжтай; 2. ш и л ж с э н язгуур угтай, угсаатай; **сурвалжит эрдэмтэн** (үе улиран эрдэм сурсан); **сурвалжит гэр** (үе улиран нэр сайтай явж ирсэн гэр); **сурвалжит баян** (үе улиран баян явсан).

СУРВАЛЖЛАГДАХ сурвалжлахын үйлдэгдэх хэв.

СУРВАЛЖЛАГЧ 1. сонин, сэтгүүлд зохих үеийн байдлыг мэдэгдэн бичигч; *сонин сурвалжлагч;* 2. ямар нэгэн юм сурвалжлан эрэгч; *орон нутгийн сурвалжлагч;* **сурвалжлагч гишүүн** (эрдэм шинжилгээний байгууллагын гишүүн бөгөөд жинхэнэ гишүүний адил бүрэн эрх үл эдэлнэ).

СУРВАЛЖЛАХ сураглах, мэдээ авчрах, нягтлах; *сурвалжлан эрэх; мэдээ сурвалжлах.*

СУРВАЛЖЛУУЛАХ 1. сурвалжлахын үйлдүүлэх хэв; 2. сурвалжлагдах.

СУРВАЛЖТАЙ уг сурвалж сайтай, сурвалж бүхий.

СУРВАЛЖТАН сурвалж бүхий хүмүүс; *ах дүүсээрээ сурвалжтан хүмүүс байгаа юм.*

СУРГААГ (АН) салаа мөчиргүй нарийн зэлгэн мод; *сургааган хашаа.*

СУРГААЛ 1. ямар нэгэн үзэгдлийн тухай онолын цогц, номлол; *байгалийн тухай сургаал; Марксын сургаал;* 2. зааж захиж, сургамжлан хэлэх үг; *өвгөн эцгийн сургаалыг даган явж байлаа.*

СУРГАГЧ ямар нэгэн зүйлийг зааварлаж сургах хүн; *мэрэгжилтэн сургагч.*

СУРГАЛТ сургах үйлийн нэр.

СУРГАМЖ 1. зааж сануулах үгс; *сургамж өгөх;* 2. зааж сануулах туршлага; *хойчид сургамж болов.*

СУРГАМЖЛАХ хүнд зааж сануулах.

СУРГАМЖТАЙ сургамж бүхий; *сургамжтай үйл явдал.*

СУРГАР у р г а м а л мөнх ногоон нарийхан навчтай, эхүүн үнэртэй, гол төлөв уулын орой, хушийн ойд ургадаг сөөг ургамал, эмнэлэгт хэрэглэнэ.

СУРГАХ 1. сурахын үйлдүүлэх хэв; *бичиг үсэгт сургах; хөдөлмөрт сургах;* 2. эмнэг морь малыг унаж, хөллөх ба ачихад дадамгай, үргэдэггүй, номхон болгох; *эмнэг сургах; морь тэргэнд сургах;* 3. хүний буруутай үйл явдлыг зааж болиулахаар хэлж ятгах; *сурган хэлж өгөх; сурахад бүү алжаа, сургахад бүү халир* з ү й р.

СУРГУУЛАХ сургахын үйлдүүлэх хэв.

СУРГУУЛИЛАХ сургууль хийлгэх, хичээллэх.

СУРГУУЛИЛУУЛАХ сургуулилахын үйлдүүлэх хэв.

СУРГУУЛЬ 1. ном эрдэм сургах газар; *бага дунд сургууль; тусгай мэрэгжлийн сургууль; улсын их сургууль; хөдөө аж ахуйн дээд сургууль; хөгжмийн сургууль; сургуулийн байшин; сургуулийн насны хүүхэд; сургуулийн хэлтэс; сургуулийн захирал;* 2. хашир үзэж, танин мэдэж авсан зүйл; *хожим сургууль болог;* 3. хичээл, дасгал; *морин цэргийн сургууль хийх; хээрийн сургууль хийх; сургууль заах; зургийн сургууль хийх;* 4. адгуус малд сургах ямар нэгэн хөдөлгөөн, үйлдэл; *сургуультай нохой; цирк сургуультай адгуус тоглоно.*

СУРЛАГА сурсан юм; *таны хүү сурлагаар сайн: сурлага муутай сураач; сурлага-хүмүүжлийн ажил.*

СУРЛАГАТАН сурлага эзэмшиж байгаа хүмүүс; *дунд сурлагатныг сайн сурлагатны хэмжээнд хүргэх.*

СУРМАГ сурамгай, дадамгай; *хонь эд бад хийхдээ их сурмаг байгаа шүү.*

СУРТАЛ 1. суртахуун, заншил; *нийтийн заншсан суртал;* **зан суртал, ёс суртал** х о р ш.; 2. улс төр, олон нийтийн чухал ажлын арга явууллагыг олон түмэнд ухуулан сэнхрүүлэхээр хийх ажил; *ард түмний дотор явуулах суртал ухуулагын ажил; суртлын хэлтэс; суртал нэвтрүүлэгч; сонгуулийн ажлыг үзэл суртлын өндөр хэмжээнд явуулах;* **үзэл суртал** (аливаа нэгэн нийгмийн анги нийгэм-улс төрийн байгуулал, чиглэлийг илэрхийлэн хамгаалсан үзэл, онол).

СУРТАЛДАХ байн байн сургаж ятгах; *сурталдаж байгаад сургаалдаа оруулав.*

СУРТАЛТАН суртал бүхий хүмүүс; *Марксын сурталтан;* **хүнд сурталтан** (албан ажилд хашин хойрго хандагчид).

СУРТАЛЧ суртал нэвтрүүлдэг хүн.

СУРТАЛЧЛАХ суртал нэвтрүүлэх; *намын бодлогыг сурталчлах.*

СУРТАЛЧЛУУЛАХ сурталчлахын үйлдүүлэх хэв.

СУРТАХУУН сурвал зохих ёс заншил; *ёс суртахуун; зан суртахуун;* **хэв суртахуун** (хэв заншил).

СУРТГУУН суртахуун.

СУРУУЛАХ сураглуулах, эрүүлэх, сурвалжлуулах.

СУРХИРАХ харвасан зэвсгийн чимээ исгэрэн дуугарах.

СУРХИРУУЛАХ сурхирахын үйлдүүлэх хэв.

СУРЦ сурах үйлийн явц; *сурц сайтай; сурцын хэмжээ дорой.*

СУРЧИН сур харвагчид.

СУУ: суу заль сүр сүлд, цог жавхлан; *суу заль нь дэлгэрэх болтугай!*

СУУВЧЛАХ сугавчлах.

СУУВЧЛУУЛАХ суувчлахын үйлдүүлэх хэв, сугавчлуулах.

СУУДАГ сууж оршдог, суурин байдаг; *суудаг байшин; хотод суудаг; суудаг гүйдэг хоёр.*

СУУДАЛ 1. суудаг юм; *энд нэг суудал байна; суудлын машин; таван хүний суудалтай; суудлын галт тэрэг;* 2. ээлж, хоног; *би энэ өдөр суудалтай, маргааш амарна.*

СУУЛГА I 1. хувин; **сав суулга** х о р ш.; *ус хийх сав суулга;* 2. будаа тариаг хэмжих сав; *таван дүүг нэг суулга гэнэ.*

СУУЛГА II чацга; **улаан суулга** (гэдэсний сочмог халдварт өвчин, *цустай суулга*).

СУУЛГАХ I 1. суухын үйлдүүлэх хэв; *дэвсгэр дээр суулгах; гэрт нь суулгах;* 2. суурьшуулах, шилжүүлэх; *хотод суулгах; шилжүүлэн суулгах;* 3. мал адгуусыг гэдрэг нь ухруулах, цахлуулах; *морио гэдрэг нь суулгах;* 4. зоох, тогтоох; *мод суулгах; шигтээ суулгах;* 5. суутгах; *цалингаас нь суулгаж авах.*

СУУЛГАХ II чацга алдах; *хүүхэд суулгаад байна.*

СУУЛГАЧ I суулгаар хэмжих ажил гүйцэтгэгч.

СУУЛГАЧ II сав суулга хийгч.

СУУЛЦАХ 1. суухын үйлдэлцэх хэв; 2. оролцох; *хуралд суулцах.*

СУУЛЦУУЛАХ суулцахын үйлдүүлэх хэв.

СУУМАЙ маш нимгэн гурилтай нэг зүйл бууз.

СУУМАЛ суусан нь; **суумал хүн** (суумгай); *суумал бурхан, гүймэл ширээ* о н ь с г о.

СУУМГАЙ сууж байхаас өөр аргагүй болсон нь.

СУУМЖ а м ь т а н янз байдал нь самжтай адил, өнгө хар, нуруунд нь бүс мэт цагаан үстэй, өмнөд хөлийн улаа маш урт цагаан үстэй амьтан.

СУУМТГАЙ суух дуртай, сууж сурсан нь.

СУУМХАЙ суух заншилтай.

СУУНАГ I доошлон тарж суусан утаа униар мэт юм; *суунаг утаа; манангийн суунаг.*

СУУНАГ II: суунаг од од харвасны дараа үзэгдэх сүүл мэт зурвас гэрэл.

СУУНАГЛАХ салхигүйд дээшээ оргилон гарсан утаа мэтийн юмны тарах, суух; *утаа суунаглах; манан суунаглах.*

СУУНАГЛУУЛАХ суунаглахын үйлдүүлэх хэв.

СУУР буга, хандгайн эврийн уг.

СУУРИГНАХ суурин болох, суурьших.

СУУРИГҮЙ 1. суурь муутай, тогтохдоо муу; 2. ш и л ж с э н болгоомж хянамжгүй, хөнгөн, булчимгүй; **байр сууригүй** х о р ш.; *ямар сууригүй ажил хийж байна даа!*

СУУРИЛАХ 1. суурь хийх, суурьтай болгох; 2. болгоомжлон хүлэгзнэх, хаширлах; 3. суурь болгох, суурь байгуулах; *хонь мал суурилах; үхэр суурилах.*

СУУРИЛУУЛАХ суурилахын үйлдүүлэх хэв, суурьт байрлуулах.

СУУРИН 1. байран, үргэлж, байнга; *хотод суурин суух;* **суурин жасаа** х у у ч и р с а н (дээр үед Нийслэлд байсан аймгийн захиргаа); 2. хөдөөний суурьшил бүхий томоохон газар; *цааш явтал нэг суурин үзэгдэв; Бараатын суурин.*

СУУРИНШИХ суурин байран шинжтэй болох, суурьших.

СУУРЬ I 1. юм тавих хэрэгсэл, тавиур; *цагны суурь; тогооны суурь;* **лааны суурь** (лаа хатгаж тогтоох хэрэгсэл); **жинсний суурь** х у у ч и р с а н (ноёд түшмэдийн малгайн жинсний дор байх зүйл); 2. довжоо; *байшингийн суурь;* **суурь довжоо** х о р ш.; 3. ямар нэгэн юмны байсан газар, буурь, ором; *хотын суурь;* **ором суурь** х о р ш.; 4. суудал, байр; **байр суурь** х о р ш.; *суурин дээрээсээ босох; сууринд нь суух;* **орон суурин** (өнгөрсөн үеийн ямар нэгэн айл буюу хүний хойт үе, үлдсэн айл өрх; *тэдний орон суурин нь болох айл*);

☆ **суурь машин** (аливаа эдлэл юмыг хийх боловсруулах машин); 5. ш и л ж с э н хашир, дэгь, буурьтай; *их суурьтай хүн байгаа юм;* **буурь суурь** х о р ш.; **буурь суурна алдах** (хөнгөн хуумгай, тогтворгүй болох); 6. ш и л ж с э н зэрэг, дэс дараа, байр; *суурь эзлүүлэх; уралдаанд явж гуравдугаар сууринд оров;* 7. ш и л ж с э н сүрэг, малын хэсэг бөөм; *таван суурь мал.*

СУУРЬ II нийгэмлэгийн тухайн үеийн хөгжлийн эдийн засгийн байгуулал.

СУУРЬТАЙ 1. суурь бүхий; 2. бат, бэх, уг сурвалж сайтай; *суурьтай барилдах;* 3. хашир, нягт, нямбай, буурьтай; *суурьтай хянаж үзэх.*

СУУРЬШИЛ суурьших үйлийн нэр; *суурьшилтай ажиллах хэрэгтэй.*

СУУРЬШИЛГҮЙ тогтворгүй, суурин байран биш.

СУУРЬШИЛТАЙ тогтвор *суурьшил сайтай.*

СУУРЬШИХ суурин байран болох; *Нийслэлд суурьших; аймгийн төвд суурьших.*

СУУРЬШУУЛАХ суурьшихын үйлдүүлэх хэв, суурин болгох.

СУУСАР а м ь т а н хул буюу хар бор өнгийн, үнэ бүхий арьстай бяцхан араатан амьтан, мөн арьс нь; *суусар малгай.*

СУУТ олны зэргээс хэтийдсэн алдартай, цуутай, нэрд гарсан нь; *суут жодоодогч; суут удирдагч.*

СУУТГАЛ суутгах үйлийн нэр; *суутгал мөнгө хэд вэ?*

СУУТГАХ өгөх олгох юмнаас шимтгэн хоцоргох, үлдээх; *цалингаас нь суутгах.*

СУУТГУУЛАХ суутгахын үйлдүүлэх хэв.

СУУХ I 1. бөгсөөрөө юман дээр тулж байх; *хөлөө чилтэл суув; дэвсгэр дээр суух; явган суух; завилж суух; нохой оцойн сууж байв;* **гэдрэг суух** (а. адуу малын гэдрэг цахлан зүтгэж тасдуулах; б. хойш суух); **хөлд нь суух** (а. адуу малын хөлд сууж тушиж барих; б. ш и л ж с э н хүнийг эвтэйхэн аргадаж ямар нэгэн юмыг зөвшөөрүүлэх); **хойш суух** (а. гэдэргээ болж суух; б. ш и л ж с э н залхуурах, бие зайлах; *хойш сууж доош малтах* з ү й р); *суух гээд чулуу шүүрэх, суниах гээд толгой цохих* з ү й р; 2. далавчит амьтны юман дээр бууж зогсох; *цонхон дээр суусан ялаа; овоо босоогүй бол шаазгай хаанаас суух вэ* з ү й р; 3. тэрэг машин зэрэг юмны хөдлөх явахад гэмтэл шалтгаан тохиолдох; *тэрэг суух; машин суух; шаварт суух; элсэнд сууж сууж гарав;* 4. ор эзлэх; *ноён суух; хаан ширээнд суух;* 5. нэмэгдэх, сайжрах; *үс суух; мах суух; өөх суух;* 6. орох; *хуралд суух; би өнөөдөр найман цагийн хичээлд суулаа; лекцинд суув;* 7. хотгор болох, доош буух, нахийх; *доошоо сууж байгаа газар; байшин суух;* 8. наалдах, тогтох, наалдан тогтох; *утаа суух; хир суух;* ☆ **марзанд суух** (ан амьтны хужир мараа идэх зам, газрыг сахиж отох).

СУУХ II 1. газар нутаг, оронд амьдрах, орших, байх, албан хаах; *хотод суух; аймгийн төвд суух; хөдөө суух; гозьд суух; сайн сууж байгаарай! айл болон амьдарч аж төрөн сууж байв; өртөөнд суух; албанд суух; хязгаарт суух; миний аав Зэлтэр харуулд сууж байв;* 2. орон байшинд орших, байх; *айлд суух; гэрт суух; гурван тасалгаатай байшинд суув;* 3. эр эм бололцон айл гэр болж амьдрах; *хүнтэй суух; охин нь Батын хүүтэй суужээ.*

СУУЦ байр, оршин суух байр, газар; **орон сууц** х о р ш.; *гурван айлын сууц; орон сууцны барилга бариулах.*

СУХАЙ у р г а м а л говь, заримдаг цөл газрын элс марзлаг хөрстэй газар бут бутаар ургадаг хатуу мод; *сухай ташуур.*

СҮВ 1. нарийхан нүх; *зүүний сүв;* 2. бэлгийн эрхтэн; *эр сүв; эм сүв;* 3. нэвтэрч болох газар; *хавцал сүв; орох гарах сүв;* **хил сүв** (хилийн боомт); 4. ш и л ж с э н арга чарга; *арга сүвийг олох.*

СҮВЛҮҮЛЭХ сүвлэхийн үйлдүүлэх хэв.

СҮВЛЭХ 1. зүүний сүвд утас хэлхэх, оруулах; *зүү сүвлэх;* 2. ш и л ж с э н арга ухаан сүвэгчлэх; *арга сүвлэх.*

СҮВРЭГ эцсийн мөгөөрсөн хавирга.

СҮВРЭГДЭС сүврэгийн орчин газар.

СҮВЭГЧ 1. зүү тэвнийн сүв; *зүүний сүвэгч;* 2. зүүний сүвд сүвлэх утасны ишрсэн нарийн үзүүр; *утсанд сүвэгч гаргах.*

СҮВЭГЧЛҮҮЛЭХ сүвэгчлэхийн үйлдүүлэх хэв.

СҮВЭГЧЛЭХ 1. арга ухаан эрэх; *арга сүвэгчлэх;* 2. сурвалжлах, олж мэдэх.

СҮВЭРХЭГ олон сүвтэй, сүв элбэгтэй.

СҮВЭЭ суганаас дооших цээжний хажуу тал; *сүвээгээр хатгах; сүвээ хавирга.*

СҮГ 1. **сүнс; сүг сүнс** х о р ш; дүрс; *хүний сүг;* **хий сүг** (шашны ба нууц далдыг шүтэх ёсонд: биегүй мөртлөө сүрхий чадалтай амьтан мэт зүйл); **сүг болох** (машид турах, дөнгөж хүн дүрс нь үлдэх); **зураг сүг** (хад чулуу зэрэг юманд сийлсэн аливаа дүрс зураг).

СҮД сэцэн, гэгээн.

СҮЕЭ ургамлын үндэс хөөж сая ургаж эхлэх нь; тарианы *сүеэ; модны сүеэ.*

СҮЕЭЛҮҮЛЭХ сүеэлэхийн үйлдүүлэх хэв.

СҮЕЭЛЭХ ургамлын үндэс язгуураас сая ургаж гарах; *тариа сүеэлж эхлэв.*

СҮЖ 1. амьтны сүү ихтэйгий нь; *сүж мал;* 2. худаг булгийн усны ундрагаа элбэгтэйгий нь; *сүж худаг;* 3. малын үр зулзагадаа хэтэрхий элэгсгий нь; *сүж үнээ.*

СҮЖИГ сүсэг.

СҮЖИГЛЭХ сүсэглэх.

СҮЖИГТЭН сүсэгтэн.

СҮЖИГЧ хэтэрхий сүжиг бүхий хүн.

СҮЗЭГ сүсэг.

СҮЗЭГЛЭХ сүсэглэх.

СҮЙ 1 х у у ч и р с а н эр эм бололцоход эрийн талаас эмийн талд өгөхөөр хэлэлцсэн юм; *өндгөн сүй; бэлэг сүй; сүй тавих;* **сүй тогтох** (хоёр этгээд өгч авах юмаа хэлэлцэж зохицох).

СҮЙ II: **сүй мана** мана чулууны нэгэн зүйл.

СҮЙ III гааль; *сүй хураах.*

СҮЙГҮЙ эр эм бололцоход сүй хэлэлцэн өгч аваагүй.

СҮЙД I хохирол, сүйдэл, сүйрэл; **сүйд майд** х о р ш.; **сүйд болох** (их л хохирол үзэх); **сүйд хийх** (хохирол сүйрэлд учруулах); **сүйдий нь хутгах** (а. сүйд болгох; б. балар будлиан болгох); **сүйдийн манан хадаах** (их л хохирол сүйдэл болгох, балар будлиан гаргах).

СҮЙД II 1. маш сүрхий дотно; *та хоёр чинь салж хагацаж чадахгүй их л сүйд болж байх шиг дээ;* 2. маш дүрсгүй, төлөв зэхий; *тэр ч тун сүйдтэй хүн дээ.*

СҮЙДЛҮҮЛЭХ 1. сүйдлэхийн үйлдүүлэх хэв; 2. сүйдлэгдэх.

СҮЙДЛЭГДЭХ сүйдлэхийн үйлдэгдэх хэв.

СҮЙДЛЭХ сүйд болгох, сүйтгэх.

СҮЙДТЭЙ сүйд бүхий; *сүйдтэй юм; сүйдтэй амьтан.*

СҮЙДҮҮЛЭХ сүйдэхийн үйлдүүлэх хэв.

СҮЙДЭЛ сүйдэх үйлийн нэр, хохирол, сүйрэл.

СҮЙДЭХ юмны гэнэтийн нөхцөл шалтгаанаар үрэгдэх бусних; *үерт сүйдэх; салхинд сүйдэх; дайн дажинд сүйдэх; амь сүйдэх; эд хөрөнгө сүйдэх.*

СҮЙЖИН усан болор.

СҮЙЛГЭЛЭХ 1. амьсгал ихэд давхцах; 2. бусдын аяд зохицуулан нийлүүлж явах.

СҮЙЛХЛЭХ огцом бачим амьсгах; *сүйлхлэн амьсгалах.*

СҮЙЛЭХ I эр эм бололцох тухай хэлэлцэн тогтох ба бэлэг сүй өгөлцөх.

СҮЙЛЭХ II амьсгал давхцах; *хүчидсэнээс амьсгал сүйлэх; гүйж харайснаас амьсгал сүйлэх.*

СҮЙЛЭХ III эд юмнаас гааль хураах.

СҮЙРҮҮЛЭХ сүйрэхийн үйлдүүлэх хэв.

СҮЙРЭЛ сүйрэх үйлийн нэр, хохирол, сүйдэл; *чингэж сүйрэлд орохгүй.*

СҮЙРЭХ элдэв аюул хөнөөлд эрсдэн үрэгдэх, сүйдэх; *өвчин тахалд сүйрэх; өр төлбөрт сүйрэх.*

СҮЙТ сүй бүхий, сүйтэй; *сүйт охин.*

СҮЙТГҮҮЛЭХ 1. сүйтгэхийн үйлдүүлэх хэв; 2. сүйтгэгдэх.

СҮЙТГЭГДЭХ сүйтгэхийн үйлдэгдэх хэв.

СҮЙТГЭГЧ хорлогч, үрэгч, бүрэлгэгч; *хорлон сүйтгэгч; бусниулан сүйтгэгч*

СҮЙТГЭЛ 1. өр, төлөөс, төлбөр; *дайны сүйтгэл; хулгайн сүйтгэл; торгууль сүйтгэл;* 2. үрэгдэл, чирэгдэл, зардал; *сүйтгэл ихтэй; сүйтгэл бага орох ажил;* 3. хуулийн байгууллагаас хэрэг зарга мэдүүлэгчдээс гаргуулан авах зарим юм.

СҮЙТГЭХ 1. сүйдэхийн үйлдүүлэх хэв; 2. юмыг зохисгүй хэтрүүлэн үрж бүрэлгэх буюу эвдлэх гээх зэргээр үгүй болгох; *үрэх сүйтгэх; мөнгө сүйтгэх;* 3. х у у ч и р с а н *юм худалдах.*

СҮЙТЭЛЗЭХ хүн амьтны өчүүхэн өчүүхэн доголох.

СҮЙХ I морь малд хөллөж хүн сууж явахад зориулан хийсэн мухлаг; *сүйх тэрэг явах; дамнуурган сүйх; жууз сүйх.*

СҮЙХ II 1. хүний чихэндээ зүүх сацаг унжлагатай ээмэг чимэг; *сүйх зүүсэн эмэгтэй;* ☆ **сүйхэн им** (малын чихийг унжуулан имнэсэн им); 2. ямар нэгэн юмны хоёр хажууд уяж унжуулсан цоморлиг: *хэнгэрэгний сүйх;* ☆ **сүйхэн цэцэг** у р г а м а л (өнгө цагаан, хүйс бяцхан, хавар эрт цэцэглэдэг нэгэн зүйл ургамал.

СҮЙХЭЭ холбоо, сүлбээ; *сүйхээ ихтэй хүн шүү.*

СҮЙХЭЭЛДЭХ хэтэрхий сүйхээлэх

СҮЙХЭЭЛЭХ дотуур далдуур, ашиг завшаан эрэлхлэн гулдран явах.

СҮЙХЭЭТЭЙ сүйхээ бүхий, сүлбээтэй, холбоотой.

СҮЛ I сөл.

СҮЛ II у р г а м а л иш улааганын иштэй адил, навч мөнх ногоон харганын навчнаас бяцхан, балчиг газарт ургана, сүлүү ч гэдэг.

СҮЛБҮҮЛЭХ сүлбэхийн үйлдүүлэх хэв.

СҮЛБЭЛДЭХ сүлбээлдэх.

СҮЛБЭХ хатган холбох, нэвт хатгах, дамжуулан хатгах; *ходоодны амсар сүлбэх; хутгаар сүлбэх; хатгаж сүлбэх; холбож сүлбэх; газар сүлбэх.*

СҮЛБЭЭ 1. холбоо; **холбоо сүлбээ** х о р ш.; 2. ураг төрлийн үе сунжирсан төрлийн улбаа; **улбаа сүлбээ** х о р ш.; *ураг удмын сүлбээтэй.*

СҮЛБЭЭЛДҮҮЛЭХ сүлбээлдэхийн үйлдүүлэх хэв.

СҮЛБЭЭЛДЭХ сүлбээлэх.

СҮЛБЭЭЛҮҮЛЭХ сүлбээлэхийн үйлдүүлэх хэв.

СҮЛБЭЭЛЭЛДЭХ сүлбээлэхийн үйлдэлдэх хэв, сүлбээлэх.

СҮЛБЭЭЛЭХ харилцан учир мэдэж, эчнээгээр нийлэх, нэгдэх, хуйвалдаж эвлэх.

СҮЛБЭЭР юмыг сүлбэх хэрэглэл; *гээзгний сүлбээр; ходоодны сүлбээр.*

СҮЛБЭЭТЭЙ 1. ураг төрлийн хамаатай; 2. хүний зайтай, зальтай; 3. холбоотой.

СҮЛД сүр жавхлан; **сүр сүлд, сүг сүлд, сүлд жавхлан** х о р ш.; **улсын сүлд** (улсын эрхэмлэн үзэх албан ёсны тэмдэг; мөнгөн тэмдэгт, улсын далбаа, албан бичгийн нүүр зэрэгт байна); **сүлд дуулал** (төрийн дуулал); **сүлд мод** (шинэ жилийн баярт чимэглэсэн гачуур мод); **сүлд модны наадам** (шинэ жилийн баярт чимэглэсэн модыг тойрон наадах наадам); **сүлд тэмдэг** (улсын сүлд); **сүлд од** з у р х а й (гэрэлт шүхэр одны доод этгээдэд буй од).

СҮЛДЭС 1. юмны учиг цуудас мэтийн юм; *хулсны сүлдэс;* 2. өө сэв, эндэл алдал; **сүлдэс эрэх** (эндэгдэл бурууг эрж хайх).

СҮЛЖ 1. ээрсэн ширхгийн ороомог бөөм; 2. утас хэрээдэслэх мод.

СҮЛЖИХ I гөрөх, сүлжих; *гээзэг сүлжих; жирэм сүлжих.*

СҮЛЖИХ II томох, *тор сүлжих; усыг нааш цааш сүлжин гатлах; өрөө тасалгаа дамжин сүлжих; модон дотуур сүлжээлэн сүлжих.*

СҮЛЖЛЭХ 1. сүлжих; 2. сүлжээ хийх.

СҮЛЖМЭЛ сүлжиж хийсэн юм; *сүлжмэл сав; сүлжмэл оосор; сүлжмэл боорцог; сүлжмэл бургасан хашаа.*

СҮЛЖҮҮЛЭХ сүлжихийн үйлдүүлэх хэв.

СҮЛЖҮҮР юм сүлжих хэрэгсэл.

СҮЛЖҮҮРЛЭХ сүлжих, сүлжээ болгох.

СҮЛЖЭЭ 1. сүлжээс; 2. хэрээ; **хэрээ сүлжээ** х о р ш.; **үгийн сүлжээ** (үг таалгах таавар).

СҮЛЖЭЭЛЭХ сүлжээ болгох, сүлжээ хийх.

СҮЛЖЭЭС сүлжисний нь, сүлжээ; *сүлжээс сайтай; сүлжээс нь задрах.*

СҮЛМҮҮ: өлмүү сүлмүү дөнгөж дангаж, арай чарай; *өлмүү сүлмүү хоолтой байна.*

СҮЛҮҮЛЭХ 1. сүлэхийн үйлдүүлэх хэв; 2. сүлэгдэх.

СҮЛЭГДЭХ сүлэхийн үйлдэгдэх хэв.

СҮЛЭХ I цай мэтэд сүү холих; *цай сүлэх.*

СҮЛЭХ II **хооронд нь хов зөөж, ховсрон** ээ найрлыг эвдэхийг хичээх; **холих сүлэх, хутгаж сүлэх** х о р ш.

СҮЛЭЭЧ ховсорч хутган үймүүлэгч зантай хүн; *сүлээч хүний үгэнд бүү урагд.*

СҮМ шашны ёсны зан үйл үйлдэх орон байр; *Буддын шашны сүм;* **дуган сүм, сүм хийд** х о р ш.. ᠰᠦᠮᠡ ᠭ

СҮМБҮМ х у у ч и р с а н бүрэн зохиол; *Зава Дамдингийн сүмбүм.* ᠰᠦᠮᠪᠦᠮ

СҮМБЭ бууны дотрыг цэвэрлэх ба сумны хонгиог түлхэхэд хэрэглэх хэрэгсэл; *бууны сумбэ; төмөр сумбэ; гуулин сумбэ.* ᠰᠦᠮᠪᠡ

СҮМБЭР: сумбэр уул манай дэлхий, сүмэр ч гэдэг; *сумбэр уулыг гүвээ байхад, сүн далайг шалбааг байхад* (аман зохиол). ᠰᠦᠮᠪᠡᠷ

СҮМГЭНҮҮЛЭХ сүмгэнэхийн үйлдүүлэх хэв. ᠰᠦᠮᠭᠡᠨᠡᠬᠦᠦᠯᠡᠬᠦ

СҮМГЭНЭХ сүүмгэнэх. ᠰᠦᠮᠭᠡᠨᠡᠬᠦ

СҮМГЭР сүүмгэр. ᠰᠦᠮᠭᠡᠷ

СҮМИЙЛГЭХ сүүмийхийн үйлдүүлэх хэв, сүүмийлгэх. ᠰᠦᠮᠢᠯᠭᠡᠬᠦ

СҮМИЙХ сүүмийх. ᠰᠦᠮᠢᠬᠦ

СҮМЭЛЗҮҮЛЭХ сүмэлзэхийн үйлдүүлэх хэв. ᠰᠦᠮᠡᠯᠵᠦᠦᠯᠡᠬᠦ

СҮМЭЛЗЭХ сүүмэлзэх. ᠰᠦᠮᠡᠯᠵᠡᠬᠦ

СҮМЭР сумбэр. ᠰᠦᠮᠡᠷ

СҮНГЭНҮҮЛЭХ сүнгэнэхийн үйлдүүлэх хэв. ᠰᠦᠨᠭᠡᠨᠡᠬᠦᠦᠯᠡᠬᠦ

СҮНГЭНЭХ 1. салхи, мотор зэрэг юмны дуугарах; *сүнгэнэтэл дуугарах; сүнгэнэн шуурах;* 2. хурдан түргэн явах; *сүнгэнэтэл давхих.* ᠰᠦᠨᠭᠡᠨᠡᠬᠦ

СҮНДЛЭХ сайн сайхан юмны, олны дотроос илрэх. ᠰᠦᠨᠳᠯᠡᠬᠦ

СҮНДЭР ноёлог, сүрт, өндөр ᠰᠦᠨᠳᠡᠷ

СҮНДЭРЛЭХ сүртэй харагдах, онцгой өндөр болон харагдах; *мөнх цаст ноёлог уулс сүндэрлэнхэн харагдаад...* (дуу). ᠰᠦᠨᠳᠡᠷᠯᠡᠬᠦ

СҮНДЭС эм хандгай. ᠰᠦᠨᠳᠡᠰ

СҮНС 1. аливаа хэрэг явдлын гол утга, оньс; *хэргийн сүнс; сүнсийг олох;* 2. шашны ёсонд: амьтныг амьдруулах хувийн эрхэн болох сэтгэл тийн мэдэл ч гэдэг; **сүнс сүлд** х о р ш.; **сүнс зайлах, сүнс халих** (ихэд айх). ᠰᠦᠨᠰ

СҮНСГҮЙ үнэнч шудрага биш; *сүнсгүй амьтан; сүнсгүй гүжирч хүн.* ᠰᠦᠨᠰᠭᠦᠢ

СҮР I хүн амьтан ба юмны гайхалтай бахдалтай буюу аймаар, болгоомжилмоор дүрс байдал; **сүр жавхлан** (цог жавхлан); **нэр сүр** (алдар нэр; *нэр сүр ихтэй; нэр сүр муутгах явдал*); **сүр ихтэй, сүр сайтай** (сүртэй, бараатай); **сүр бараа** (бараа ихтэй); **сүр гаргах, сүр бадруулах, сүр үзүүлэх** (санаатайгаар сүртэй байдал гаргах, сүрдүүлэх); **сүр яс** (барсын омрууны хоёр хажуугийн маханд байх сул яс); **газрын сүр** (өндөр газар явснаас болж тусах нэг зүйл өвчин). ᠰᠦᠷ

СҮР II: **сүр сүр, сүр сар** салхи салхилах, хөдлөх зэрэгт гарах чимээ.

СҮРГАР сургар. ᠰᠦᠷᠭᠡᠷ

СҮРДҮҮ 1. сүржин; 2. сүрдэмтгий. ᠰᠦᠷᠳᠦᠦ

СҮРДҮҮЛЭГ сүр үзүүлсэн үйл ажиллагаа; *дайсны сурдуулгээс айж болохгүй.* ᠰᠦᠷᠳᠦᠦᠯᠡᠭ

СҮРДҮҮЛЭГЧ сүрдүүлдэг, сүрдүүлэх этгээд. ᠰᠦᠷᠳᠦᠦᠯᠡᠭᠴᠢ

СҮРДҮҮЛЭХ сүрдэхийн үйлдүүлэх хэв, айлгах, эмээлгэх. ᠰᠦᠷᠳᠦᠦᠯᠡᠬᠦ

СҮРДЭМТГИЙ сүрдэх зантай, сүрдэмхий. ᠰᠦᠷᠳᠡᠮᠲᠭᠢᠢ

СҮРДЭМХИЙ сүрдэх зантай, сүрдэмтгий. ᠰᠦᠷᠳᠡᠮᠬᠢᠢ

СҮРДЭХ юмны сүрээс эмээх болгоомжлох. ᠰᠦᠷᠳᠡᠬᠦ

СҮРЖИН сүр бадруулamтгай; *сурхий сүржин хүн.* ᠰᠦᠷᠵᠢᠨ

СҮРЛЭГ сүр ихтэй; *сүрлэг уул; сүрлэг амьтан; сүрлэг өндөр Алтай ууланд шүүдэр хяруу унаад...* (дуу). ᠰᠦᠷᠯᠡᠭ

СҮРСЭГ а м ь т а н янз нохойтой адилхан болоод урт сүүлтэй гөрөөс. ᠰᠦᠷᠰᠡᠭ

СҮРТ сүр бүхий: **сүрт жагсаал** (нийгэм-улс төрийн бодлогыг илэрхийлэн олноор жагсах жагсаал). ᠰᠦᠷᠲᠡ

СҮРТЭЙ 1. сүр ихтэй; *сүртэй амьтан; чоно заавал сүртэй харагддаг;* 2. бараа ихтэй; *сүртэй ачаа.* ᠰᠦᠷᠲᠡᠢ

СҮРХИЙ аймшигтай, гайхалтай, тун, асар, маш, туйлын, их; *сурхий сайхан; сурхий муухай; сурхий хэцүү; сурхий хэрэг; сурхий дуу; сурхий салхи; сурхий уул; сурхий араатан; сурхий амт; сурхий үнэр; сурхий хурц; сурхий халуун; сурхий ааштай; сурхий зовлонтой хэрэг болж байна.* ᠰᠦᠷᠬᠢᠢ

СҮРХРЭХ сүр сүр хийж дуугарах. ᠰᠦᠷᠬᠦᠷᠡᠬᠦ

СҮРЧИГ сүрчих үнэртний зүйл. ᠰᠦᠷᠴᠢᠭ

СҮРЧИХ ус зэрэг шингэн зүйлийг юман дээр сацах, шүрших. ᠰᠦᠷᠴᠢᠬᠦ

СҮРЧЛЭГ сүршлэг, ᠰᠦᠷᠴᠢᠯᠡᠭ

СҮРШИХ сүрчих; *ус сүрших; газар сүрших.*

СҮРШЛЭГ 1. сүрчихэд хэрэглэгдэх юм; 2. сүрчих багаж хэрэглэл.

СҮРШҮҮР сүршдэг юм.

СҮРШҮҮЛЭХ сүршихийн үйлдүүлэх хэв.

СҮРШҮҮР сүршлэг, сүрших хэрэгсэл, шүршүүр.

СҮРЬЕЭ уушиг, яс зэрэгт тусах халдварт өвчин; *сүрьеэгийн больниц; уушигны сүрьеэ; ясны сүрьеэ.*

СҮРЭГ амьтны аймаг төрлөөр буюу хэсэг бүлгээр нэг газар бүхий бөөгнөрөл; *хонин сүрэг; зээрийн сүрэг; хулан сүрэг сүргээр явна; шувууны сүрэг; мал сүрэг; баян Монголын хонь ямаан сүрэг өө хөө хөө* (дуу); **сүрэг тавих** (малаасаа өөр айлд тавих); **сүрэг хадгалах** (бусдын мал хадгалах); **төмөр сүрэг** (ямар ч шалтгаан тохиолдсон тоо бүрэн байлгах сүрэг); **сүрэг тамга** (таван нүд гаргасан нэг зүйл тамга).

СҮРЭГЛҮҮЛЭХ сүрэглэхийн үйлдүүлэх хэв.

СҮРЭГЛЭЛ бүлэглэл, бөөгнөрөл.

СҮРЭГЛЭХ амьтны сүрэг болон нийлэх, нийлүүлэх, нэгтгэх; *малаа сүрэглэх; хоршооны мал сүрэглэх.*

СҮРЭГЧИН сүрэг адуулах айл буюу хүн.

СҮРЭЛ тариа будааны иш эвс.

СҮРЭЛЛЭХ тарианы иш сүрлийг салгах.

СҮРЭЭ сүрлэг, сүртэй.

СҮСЛЭХ баясан бишрэх, сүсэглэх.

СҮСЭГ батад итгэсэн санаа, шашны ёсны бишрэл, сүжиг, сүзэг; **сүсэг бишрэл** х о р ш.; *мухар сүсэг.*

СҮСЭГЛҮҮЛЭХ 1. сүсэглэхийн үйлдүүлэх хэв, сүжиглүүлэх, сүзэглүүлэх; 2. сүсэглэгдэх, сүжиглэгдэх, сүзэглэгдэх.

СҮСЭГЛЭГДЭХ сүсэглэхийн үйлдэгдэх хэв.

СҮСЭГЛЭХ баясч бишрэх, итгэмжлэн хүсэх, сүжиглэх, сүзэглэх.

СҮСЭГТЭЙ сүсэг бүхий, бишрэл ихтэй, сүжигтэй, сүзэгтэй.

СҮСЭГТЭН сүсэг бүхий хүмүүс, сүжигтэн, сүзэгтэн.

СҮҮ (Н) амьтны хөхнөөс гарах цагаан шарангүй өнгөтэй шингэн зүйл; *эхийн сүү; сүүн тэжээлтэй; сүүтэй цай; сүү сааль, гаргаг сүү;* **богшоосон сүү** (өтгөрүүлж, лаазанд хийсэн сүү); **борцолсон сүү** (хатааж талхалсан сүү); **сүү өргөх** (бэлэг єрөөл тавьж, сүү цацах); **сүүний тослог** (сүүнд байх тосны хувь); **сүү шиг дотортой** (цагаан санаатай); **сүүн хорс** у р г а м а л (иш өндөр, навч суйхын навчны адил, цэцэг хөх, хор их, суманд түрхэж гөрөөс алдаг гэдэг); **сүүн үндэс** у р г а м а л (усанд ургана, янз саримсгийн адил, хэлтэсгүй, өнгө хар, амт амтайхан).

СҮҮГҮЙ сүү байхгүй; *сүүгүй мал сүж, сүсэггүй лам мөргөөч* з ү й р.

СҮҮДЭВЧ нарыг халхлан байгуулсан юм.

СҮҮДЭГНҮҮЛЭХ сүүдэгнэхийн үйлдүүлэх хэв.

СҮҮДЭГНЭХ сүүтэгнэх.

СҮҮДЭР I юмны гэрэл, юманд халхлагдаж гэрэл нь тусаагүй хэсэг газар; *уулын сүүдэр гэрийн сүүдэр; өвсний сүүдэр; сүүдэрт суух; сүүдэрт орох; сүүдэр тал; сүүдрийн бараа нь их боловч барьж болдоггүй, сүүний өнгө нь цагаан боловч будаж болдоггүй з ү й р;* **сүүдэр барих** (сүүдэрлэх юм барих); **сүүдэрт шүхэр** (нарны гэрэл гялбааг халхлах халх); **сүүдэр зураг** (кино); **сүүдэртэй тал** ш и л ж с э н базаахгүй, муу тал; *сүүдэртэй талы нь ашиглах);* **сүүдэр өвчин** (хүний бие ба зарим эрхтний мэдрэл алдрах өвчин).

СҮҮДЭР II нас; **нас сүүдэр** х о р ш.; *энэ жил таны нас сүүдэр хэд хүрч байна?*

СҮҮДЭРЛҮҮЛЭХ 1. сүүдэрлэхийн үйлдүүлэх хэв; 2. сүүдэрлэгдэх.

СҮҮДЭРЛЭГДЭХ сүүдэрлэхийн үйлдэгдэх хэв.

СҮҮДЭРЛЭХ нар, гал зэргийн гэрэл бүхий юмны гэрэл илчийг халхлах, халхлагдах.

СҮҮДЭРТҮҮЛЭХ сүүдэртэхийн үйлдүүлэх хэв, сүүдэртэй болгох.

СҮҮДЭРТЭЙ сүүдэр сайтай, сүүдэр ихтэй.

СҮҮДЭРТЭХ I сүүдэртэй болох.

СҮҮДЭРТЭХ II сүүдэр өвчин тусах.

СҮҮДЭХ нялх хүүхэд ба нялх төлийн хөхсөн сүү ихдэж сүүн өнгөөр баах.

СҮҮЖ хүн амьтны гуяны дунд чөмөгний дээд этгээдэд уулгай холболдон байдаг нухтэй яс; *сүүжний яс.*

СҮҮЛ 1. аливаа юмны хойт, адаг, бөгс, төгсгөл, шувтрага; *майхны сүүл; наадмын сүүл; номын сүүл; онгоцны сүүл;* **сүүлийн тэмээний ачаа хүнд** (юмны эцэс, төгсгөл шувтрага нь хүнд, жинтэй, их); **сүүлийн сонин** (а. сүүлийн үеийн мэдээ; б. сүүлийн үеийн сонин бичиг, сонин зүйл); **сүүлийн өдрүүдэд** (саяхны өдрүүдэд, ойрын өдрүүдэд); **сүүлийн хэдэн хоног** (саяхны ойрын хэдэн хоног); 2. мал гөрөөс зэрэг амьтны нурууны журмын ясны үзүүр этгээдийн яс, мах, өөх, арьс, үс; *хонины сүүл; годон сүүл; нохойн сүүл; нохой сүүлээ, сүүл хонгорцоо* з ү й р; ☆ **сүүл хавчих** (а. сүүл дарах; б. ш и л ж с э н ихэд айх); **сүүл агсах** (сүүл сөхөх); **сүүл сөхөх** (а. сүүл өргөх; б. ш и л ж с э н дээрэлхэх); **сүүл барих, сүүл мушгих** (а. аливаа юмнаас үлдэж хоцрох, хожимдох; *сүүл барьж, сүүдэрт нуугдах* з ү й р; б. аливаа уралдаан тэмцээн зэрэгт хоцрох, сүүлдэх, адагт орох); **сүүл дарах** (а. сүүл мушгих; б. ойролцоо газар мөрдөн хөөх, гэзэг дарах); **сүүлээ сэрвээ дээрээ тавих** (а. биеэ тоох; б. дээрэлхэх; *сүүлээ сэрвээндээ тавьж, сух барьж, хүн айлгах* з ү й р).

СҮҮЛД дараа. хожим, хойно; *сүүлд уулзъя; танайд сүүлд очно; миний сүүлд ирээрэй; ажлын сүүлд болъё; амьтны сүүлд орохгүй.*

СҮҮЛДҮҮЛЭХ 1. сүүлдэхийн үйлдүүлэх хэв; 2. сүүлдэгдэх.

СҮҮЛДЭГДЭХ сүүлдэхийн үйлдэгдэх хэв.

СҮҮЛДЭХ 1. амьтны сүүлнээс барьж татах; 2. бусдаас хожимдох, хоцрох.

СҮҮЛТ сүүл бүхий; **хар сүүлт** а м ь т а н (сүүлтэй): **сүүлт од** (бүдэг гэрэлт толбо бүхий буюу сүүл мэт гэрэлт зурвас бүхий тэнгэрийн эрхэс).

СҮҮЛТЭЙ а м ь т а н зээртэй адил болоод сүүл урт нэгэн зүйл гөрөөс; *сүүлтэй зээр.*

СҮҮЛЧ эцэс, төгсгөл; *дэвтрийн сүүлч; шинжилгээний ангийн сүүлч ирэв;* **сүүлчийн удаа** (эцсийн удаа); **сүүлчийн зам** (эцсийн зам).

СҮҮЛЭХ цай дээр сүү хийх; *цай сүүлэх.*

СҮҮЛЭЭР дараа, хожим; *чи бид хоёр энэ тухай сүүлээр ярья.*

СҮҮМГЭР бараг бүрэн үзэгдэх юм; *сүүмгэр гэрэл.*

СҮҮМГЭРДЭХ хэтэрхий сүүмгэр болох.

СҮҮМИЙЛГЭХ сүүмийхийн үйлдүүлэх хэв, сүүмгэр болгох.

СҮҮМИЙХ сүүмгэр болох; *гэрэл сүүмийгээд юу ч харагдахгүй байна.*

СҮҮМХИЙ I юмны өнгө тодорхойгүй.

СҮҮМХИЙ II 1. бядуу хөдөх хүн; 2. нүд нь бүдэх хүн.

СҮҮМЭГНҮҮЛЭХ сүүмэгнэхийн үйлдүүлэх хэв.

СҮҮМЭГНЭХ 1. сүүмгэр юмны үргэлжлэн хөдлөх байдал; 2. гэрэл, бараа алсаас сүүмэлзэн үзэгдэх.

СҮҮМЭЛЗҮҮЛЭХ сүүмэлзэхийн үйлдүүлэх хэв.

СҮҮМЭЛЗЭХ сүүмгэр юмны байн байн хөдлөх.

СҮҮРС: сүүрс алдах санаа алдах.

СҮҮТ: сүүт өвс иш навч үндэс зэргээс сүү мэт өтгөн цагаан шүүс гардаг бүлэг ургамлын ерөнхий нэр.

СҮҮТГЭЛЗЭХ сүүтгэр юмны байн байн хөдлөх.

СҮҮТГЭР сүүмгэр.

СҮҮТЭГНҮҮЛЭХ сүүтэгнэхийн үйлдүүлэх хэв.

СҮҮТЭГНЭХ юмны бараа нь бүрэг бараг, сүүдрийн төдий хөдлөн үзэгдэх.

СҮҮТЭЛЗҮҮЛЭХ сүүгэлзэхийн үйлдүүлэх хэв.

СҮҮТЭЛЗЭХ сүүтгэр юмны сүүтэс сүүтэс хийх.

СҮҮХЭЭ сүйхээ.

СҮХ юм хум цохих, хагалахад хэрэглэх зэвсэг; *том сух; жижиг сух; хангинуур сух; тал сух; сухний иш; сухээр цавчих;* **сух далайтал үхэр амрах** (түр боловч чөлөөтэй болох)

СҮХДҮҮЛЭХ сүхдэхийн үйлдүүлэх хэв, сүхээр цохиулах, дэлдүүлэх.

СҮХДЭХ сүхээр цохих, цавчих, дэлдэх.

СҮХЛЭХ сүхээр цавчих, цохих.

СҮХЭВЧ жижигхэн сүх.

СЭВ I 1. юмны өө; **өө сэв** х о р ш.; 2. юмны будаг зэргийн холтрох, ховхрох зэргээр гэмтсэн гэмтэл; *будаг нь сэв гарчээ;* 3. цэвэр юманд наалдсан бага сага буртаг мэтийн

зүйл; *буртаг сэв;* 4. гилгэр юманд гарсан хортон; *хортон сэв гарчээ;* 5. хүний үс гэзгийг самнахад гарсан үс; *гээгний сэв;* 6. ш и л ж с э н гэмтэй; *сэвтэй хүн сээрээ маажна* з ү й р; **сэв эрэх** (өө харах).

СЭВ II «С»-ээр эхэлсэн үгийн өмнө хэрэглэх хүч нэмэгдүүлэх үг; **сэв сэрүүн** (бүр сэрүүн); **сэв сэм** (нам гүм, чив чимээгүй, дув дугуй); **сэв сэв хийх** (а. амьтны сэмээр алхлан явах; б. үе үе сэгхийх; в. зөөлөвтөр салхи салхилах; *сэв сэв салхилах;* г. жижиг амьтны нисэх).

СЭВГҮЙ гэм өөгүй, бохир буртаггүй.

СЭВГЭР 1. бага хүүхдийн үс гээгэр; 2. зарим газар хүүхэн гэсэнтэй адил утгаар хэрэглэнэ.

СЭВЛҮҮЛЭХ сэвлэхийн үйлдүүлэх хэв.

СЭВЛЭГ 1. нялх хүүхдийн үс; 2. зарим ургамлын үндсэнд буй сахал мэт зүйл.

СЭВЛЭХ халуун буцламгай юмыг хүйтэн юмаар сэвэх.

СЭВРЭХ нойтон чийгтэй юмны хатаж эгших, эврэх.

СЭВРЭЭГҮЙ хатаагүй, эгшээгүй эврээгүй.

СЭВРЭЭХ сэврэхийн үйлдүүлэх хэв, сэврүүлэх; *салхинд сэврээх.*

СЭВС хивэгч амьтны гүзээн доторхи баас.

СЭВСГЭР хөвсгөр, зөөлөн; *сэвсгэр шороо; сэвсгэр цас; сэвсгэр аргал.*

СЭВСДЭХ хэтэрхий сэвс болох.

СЭВСИЙЛГЭХ сэвсийхийн үйлдүүлэх хэв, сэвсгэр болгох.

СЭВСИЙХ сэвсгэр байдалтай болох.

СЭВСЛҮҮЛЭХ 1. сэвслэхийн үйлдүүлэх хэв; 2. сэвслэгдэх.

СЭВСЛЭГДЭХ сэвслэхийн үйлдэгдэх хэв.

СЭВСЛЭХ юмыг сэвсээр хөхүүлэх.

СЭВСРЭХ 1. лууван зэргийн юмны муудаж дотроо хөвөн мэт болох; 2. юмны сэвс мэт болох; 3. халирч гулчийх.

СЭВСТЭХ юмыг сэвсээр хөхүүлэх, тэмээний сэвсээ гаргаж хаях.

СЭВСҮҮЛЭХ сэвсэхийн үйлдүүлэх хэв,

СЭВСЭХ савсах.

СЭВТҮҮЛЭХ сэвтэхийн үйлдүүлэх хэв.

СЭВТЭХ юманд өө сөв тогтох, сэвтэй болох.

СЭВТЭЭХ сэвтэхэд хүрүүлэх, сэвтүүлэх.

СЭВҮҮН I 1. сонин гайхалтай; **сонин сэвүүн, сэвүүн гайхалтай** х о р ш.; **сэвүүн үг** (сонин гайхам үг); **сэвүүн юм** (гайхмаар сонин сайхан юм); **сэвүүн амсах** (урьд үзээгүй шинэ сонин юм анх удаа тохиолдож үзэх, амтлах); 2. тааламжтай; *сэвүүн салхи.*

СЭВҮҮН II хирээс хэтэрхий дээгүүр зан байдалтай; *сэвүүн зантай; сэвүүн санаатай зэвүүн хүн байна.*

СЭВҮҮР сэвэх хэрэгсэл, дэвүүр.

СЭВҮҮРХЭХ идэх юмыг үе үед нэгэнт идэж сонирхох.

СЭВХ 1. хүний нүүрт гарсан мэнгэ адил жижиг зүйл; 2. чийгтсэнээс болж юманд тогтсон тор толбо мэт юм.

СЭВХИЙЛГЭХ сэвхийхийн үйлдүүлэх хэв.

СЭВХИЙХ 1. алжаасан цуцсан нь түр амарч тэнхрэх; *түр боловч сэвхийгээд авья;* 2. халууцсан нь бага зэрэг сэрүүцэх; *хөлс сэвхийх;* 3. нойтон нь бага зэрэг эгших; *угаасан юм сэвхийж байна;* 4. хүн амьтны хөнгөн хөдлөх; *сэвхийтэл мордов; гэнэт сэвхийн орж ирэхэд...*

СЭВХТЭХ сэвх тогтох, сэвх гарах.

СЭВШЭЭ: сэвшээ салхи тааламжтай, урьхан, сайхан салхи.

СЭВШЭЭЛЭХ сэвшээ салхи салхилах; *намрын хонгор салхи сэвшээлэн салхилж байна.*

СЭВЭГ хулс, мод, туйвангийн зэргээр сүлжиж хийсэн юм хум агуулах сав; *цайны сэвэг; сийрсэн сэвэг.*

СЭВЭГНҮҮЛЭХ сэвэгнэхийн үйлдүүлэх хэв.

СЭВЭГНҮҮР сэвэлзүүр.

СЭВЭГНЭХ 1. юмны салхинд бага зэрэг хөдлөх; *үс сэвэгнэх;* 2. хүч багатайгаар салхилах; *салхи сэвэгнэх;* 3. хөнгөн хөдлөх; *сэвэгнэсэн хөнгөн хүн байна шүү.*

СЭВЭЛЗҮҮЛЭХ сэвэлзэхийн үйлдүүлэх хэв.

СЭВЭЛЗҮҮР 1. сэвэлзсэн сэвэгнүүр урьхан салхи; *сэвэлзүүр салхи үлээж байна;* 2. хөнгөн гавшгай хөдөлгөөнтэй; *гялалзсан сэвэлзүүр хүн;* 3. хөнгөн хийсвэр; *сэвэлзүүр зантай хүн.*

СЭВЭЛЗЭХ 1. сэвэгнэх; *салхи сэвэлзэхийн хамт;* 2. хүн амьтны хөнгөн гавшгай хөдлөх; *сэвэлзсэн сүрхий өвгөн байна билээ.*

СЭВЭХ I 1. халуун юмыг салхи хийгээр цохих буюу салхи оруулах, салхинд тохиолдуулах, *үлээж сэвэх; дэвж сэвэх;* 2. нойтон чийгтэй юмыг салхинд гаргах, сэврээх; *салхинд сэвэх;* 3. буцламгай юман дээр хүйтэн ус бага зэрэг дусаах; *ус дусааж сэвэх;* 4. зөөлөн салхины үлээх: *салхи сэвэх.*

СЭВЭХ II болшгүй, бүтэшгүй юманд санаа сэдэх; *сэвэхгүй юманд сэвж ажлаа алдах хэрэггүй.*

СЭГ I 1. чоно араатны барьж идээд үлдсэн амьтны үлдэгдэл; *хонины сэг; гөрөвсний сэг;* 2. элэгдэж эвдэрсэн юмны үлдэгдэл тамтаг; *дээлийн сэг; манай гэр бүр ч сэг болж гүйцэв;* 3. эрэмдэг зэрэмдэг болсон; *өвчний сэг болсон амьтан;* 4. зэмдэг, тэмдэг; **сэг зэмдэг, сэг тэмдэг** х о р ш..

СЭГ II завсарлах, түр зогсголзох; *ажил сэг хийх; бороо сэг хийх.*

СЭГГҮЙ тасралт зогсолтгүй үргэлжлэх; *сэггүй ажилладаг хүн; бороо сэггүй орж байна; сэггүй шуурхай ажиллаад ажлаа түргэн дуусгавал зохино.*

СЭГЛИЙ сэгэл I.

СЭГЛИЙЛГЭХ сэглийхийн үйлдүүлэх хэв, сэглэгэр болгох.

СЭГЛИЙХ сэглэгэр болох.

СЭГЛЭГ морь малын нэгэн зүйл явдал; *морины сэгэлгээр явсаар ирэв.*

СЭГЛЭГЭР саглагар, сэгсгэр; *сэглэгэр үстэй малгай.*

СЭГЛЭХ I сэг, зэмдэг, тамтаг болгох; *ажил сэглэж орхих; номоо сэглэх; мах эвдэх гэж* сэглэчжээ.

СЭГЛЭХ II сэгхийх, зогсголзох, амсхийх.

СЭГРЭХ сэг болох, тамтрах.

СЭГС өвсөөр хийсэн нэгэн зүйл сав.

СЭГСГЭР амьтны үс ихэд ургаж, эе эвгүй болсны нь; *сэгсгэр үстэй хүүхэд; сэгсгэр үстэй нохой.*

СЭГСГЭРХЭН арай сэгсгэр, нилээд сэгсгэр.

СЭГСИЙЛГЭХ сэгсийхийн үйлдүүлэх хэв, сэгсгэр болгох.

СЭГСИЙХ сэгсгэр болох.

СЭГСРҮҮЛЭХ 1. сэгсрэхийн үйлдүүлэх хэв; 2. сэгсрэгдэх.

СЭГСРЭГДЭХ сэгсрэхийн үйлдэгдэх хэв.

СЭГСРЭЛТ сэгсрэх үйлийн нэр; *сэгсрэлтийн ая даахгүй.*

СЭГСРЭХ 1. аливаа юмны шороо тоосыг дэвж гүвэх; *ширдгээ сэгсрэх;* 2. хүн амьтны толгойгоо сэжиж хөдөлгөх; *толгойгоо сэгсрэх;* 3. үйл ажлыг биедээ холбогдуулахгүй болгон зайлуулахыг хичээх; *хавитуулахгүй сэгсэрч байв.*

СЭГСҮҮРЭГ сэнс арьс; *нарийн сэгсүүрэг.*

СЭГСЧИХ юмыг байн байн сэгсрэх.

СЭГСЧҮҮЛЭХ сэгсчихийн үйлдүүлэх хэв.

СЭГСЭГНҮҮЛЭХ сэгсэгнэхийн үйлдүүлэх хэв.

СЭГСЭГНЭХ сэгсгэр юмны сэгсэг сэгсэг хөдлөх.

СЭГСЭЛЗҮҮЛЭХ сэгсэлзэхийн үйлдүүлэх хэв.

СЭГСЭЛЗЭХ сэгсгэр юмны сэгсэс сэгсэс хийх.

СЭГХИЙЛГЭХ сэгхийхийн үйлдүүлэх хэв.

СЭГХИЙХ 1. хийж байсан үйл явдлаа түр зогсож амсхийх; 2. өрсөн бороо, цас, салхилсан салхи шуурга зэргийн түр зогсголзож арилах, тогтнох; 3. юмыг гүйцэд хийхгүй, дутуу хагас орхих, хэрэгцээг алдуулах, гутаах зэргээр сэглэх.

СЭГЭЛ I 1. өвсөөр хийсэн дэвсгэр; 2. малын дор дэвссэн өвс.

СЭГЭЛ II: **сэгэл санаа** дээгүүр, сэхүүн санаатай; *сэгэл санаа ширээ дээр, ширэн хавтга ташаа дээр гэгчээр...*

СЭГЭЛГЭХ сэгэхийн үйлдүүлэх хэв; *морио сэгэлгэх.*

СЭГЭЛДРЭГ юмны уях торгох оосор, сагалдрага; *малгайн сэгэлдрэг; нохойн сэгэлдрэг; ташуурын сэгэлдрэг.*

СЭГЭЛДРЭГЛҮҮЛЭХ сэгэлдрэглэхийн үйлдүүлэх хэв.

СЭГЭЛДРЭГЛЭХ сагалдрагалах.

СЭГЭХ шогших хатрих хоёрын хоорондох явдлаар явах.

СЭГЭЭ ухаа, самбаа; *сэгээ орох; сэгээ гаргах.*

СЭГЭЭЛЭХ сэгээ гаргах, самбаалах.

СЭГЭЭРҮҮЛЭХ сэгээрэхийн үйлдүүлэх хэв.

СЭГЭЭРЭХ сэгээ орох, самбаа орох.

СЭГЭЭТЭЙ сэгээ бүхий, самбаатай, овтой.

СЭДЛЭГ сэдэх үйлийн нэр, өдлөг.

СЭДРҮҮЛЭХ сэдрэхийн үйлдүүлэх хэв.

СЭДРЭХ 1. яр шархны улам ихдэх; *хатиг сэдрэх;* 2. нэг юмнаас **нөгөө** үйл хэрэг удран гарах; *хэрэг сэдрэх.*

СЭДРЭЭХ сэдрэхэд хүргүүлэх, сэдрүүлэх.

СЭДҮҮЛЭХ сэдэхийн үйлдүүлэх хэв.

СЭДЭВ I 1. үйл явдлыг үүсгэхэд холбогдсон шалтгаан; 2. нууц хэргийн сэрэгдүүлэх, сэжигдүүлэх шалтгаан болох баримт; *хэргийн сэдэв мэдэгдэх.*

СЭДЭВ II бичиг зохиол, илтгэл, мэдээлэл зэргийн товч гаргалга.

СЭДЭВЛҮҮЛЭХ сэдэвлэхийн үйлдүүлэх хэв.

СЭДЭВЛЭГДЭХ сэдэвлэхийн үйлдэгдэх хэв, сэдэв мэдэгдэх.

СЭДЭВЛЭХ I үйл явдлыг анх үүсгэх; *сэдэвлэн зохиогч.*

СЭДЭВЛЭХ II юмны сэдвийг мэдээд түүгээр баримт болгох.

СЭДЭРГЭНЭ у р г а м а л говь цөл газар ургадаг, ягаан цэцэгтэй, жижиг өргөстэй бутлаг ургамал.

СЭДЭХ үйл юмыг анх сэдэвлэн үүсгэх; **өдөх сэдэх** х о р ш.; *санаа сэдэх; хэрэг сэдэх.*

СЭЖИГ 1. юманд битүү тааварлан хардах; *сэжиг санах; хар сэжиг;* 2. бузар муухай юмнаас жигших сэтгэл; *сэжиг хүрэх; сэжгээр чөтгөр, сүзгээр бурхан* з ү й р; *сэжгээр өвдөх, сүзгээр эдгэх* з ү й р; 3. ажиг, таавар; **ажиг сэжиг, сэжиг таавар** х о р ш..

СЭЖИГГҮЙ 1. юмнаас жигшихийг мэдэхгүй; *сэжиггүй бол сүсэггүй, сүсэггүй бол сэжиггүй* з ү й р; 2. буєдыг хардах сэтгэлгүй, хар хоргүй; 3. юманд сэжиглэх баримт сэдэв гарахгүй.

СЭЖИГДЭХ I сэжихийн үйлдэгдэх хэв.

СЭЖИГДЭХ II сэжиг санах.

СЭЖИГЛҮҮЛЭХ 1. сэжиглэхийн үйлдүүлэх хэв; 2. сэжиглэгдэх.

СЭЖИГЛЭГДЭХ сэжиглэхийн үйлдэгдэх хэв.

СЭЖИГЛЭЛ сэжиглэх үйлийн нэр.

СЭЖИГЛЭЛТЭЙ сэжиглэл бүхий; *сэжиглэлтэй явдал байна даа.*

СЭЖИГЛЭМТГИЙ сэжиглэх зантай, сэжиглэмхий.

СЭЖИГЛЭМХИЙ сэжиглэх зантай, сэжиглэмтгий.

СЭЖИГЛЭХ 1. аливаа үйл явдлын мөн бурууг тогтооход энэ тий ийм болов уу гэж төсөвлөн тааварлах буюу хардах, сэжигдэх; 2. бузар муухай юмнаас жигшиж дургүй хүрэх.

СЭЖИГТЭЙ сэжиг бүхий; *сэжигтэй хүн.*

СЭЖИГЧ бузар муухай юмнаас жигшимтгий; *их сэжигч хүн байна билээ.*

СЭЖИХ 1. эрэртэй амьтны буєдыг өрөөсөн эврийн үзүүрээр олих; 2. амьтны толгойн хажуу этгээдээр олих, толгойгоо займрах.

СЭЖЛҮҮР сэжиж хөдөлгөх хэрэгсэл.

СЭЖЛЭХ байн байн сэжих, олноороо сэжих.

СЭЖҮҮЛЭХ сэжихийн үйлдүүлэх хэв, мөргүүлэх.

СЭЖҮҮР юмны зах үзүүр; *борооны сэжүүр дайраа; үгний сэжүүр сонсдов; дээлийн сэжүүр усанд дүрэв.*

СЭЖҮҮРДЭХ зах сэжүүр дайралдах, тохиолдох.

СЭЖҮҮРЛЭХ сэжүүрдэх, дайралдах, тохиолдох.

СЭЛБҮҮЛЭХ сэлбэхийн үйлдүүлэх хэв.

СЭЛБҮҮР сэлүүр; *усан онгоцны сэлбүүр;* **сэлбүүр хөлтөн** (сэлүүр мэт хөлтэй, далайн амьтад).

СЭЛБҮҮРДЭХ сэлбүүрээр сэлэх.

СЭЛБЭГ 1. эвдэрсэн элэгдсэн юмыг сэлбэхэд оруулах зүйл; *сэлбэг хэрэгсэл;* 2. үйл явдалд хэрэглэгдэх зүйл дутагдах тухайд нөхөх туслахаар зориулсан зүйл.

СЭЛБЭГНЭХ сэлбэгэр юмны үргэлжлэн хөдлөх.

СЭЛБЭГЭР салбагар, нэвсгэр, унжиж санжсан.

СЭЛБЭЛЗЭХ хүн амьтны ийш тийш сэртвэлзэн хялбалзан хөдлөх, харах.

СЭЛБЭЛЭГ сэлбэх үйлийн нэр, сэлбэлгээ; *сэлбэлэг их орно; сэлбэлэг багатай.*

СЭЛБЭХ I хуучирсан, элэгдсэн эвдэрсэн юмыг сайжруулахаар засах; **сэлбэх засах** х о р ш.; 2. халуун буцламгай юман дээр хүйтэн юм нэмж хийх; *цай сэлбэж залгилав.*

СЭЛБЭХ II онгоцыг сэлбүүрээр хөдөлгөн явах, сэлүүрдэх; *онгоц сэлбэх.*

СЭЛБЭЭС сэлбэг, сэлбэсэн нь.

СЭЛГҮҮЛЭХ сэлгэхийн үйлдүүлэх хэв.

СЭЛГҮҮР сэлгэх юм. ◆

СЭЛГҮҮЦҮҮЛЭХ сэлгүүцэхийн үйлдүүлэх хэв, сэлгүүцэхэд хүргүүлэх.

СЭЛГҮҮЦЭХ сэлгэцэх; *гудамжаар дэмий сэлгүүцэх.*

СЭЛГЭЛЭГ сэлгэх үйлийн нэр; *сэлгэлэг хийх.*

СЭЛГЭХ 1. сэлэх, солих, ээлжлэх; *тариаланг сэлгэж тарих; нутаг сэлгэх;* 2. сэлгүүцэх, хэсэх тэнэх; *өрөө тасалгаа сэлгэх;* ☆ **авиа сэлгэх** (нэгэн авиа өөр авиагаар солигдох).

СЭЛГЭЦ сэлгэх явцын нэр, сэлгэх нь.

СЭЛГЭЦЭХ хүн амьтны ирэх очих нь тасралтгүй буюу үүгээр түүгээр дэмий зугаахийн явах.

СЭЛДИЙ эр адгуусны бэлгийн эрхтэн.

СЭЛТ дашрамын юм; *нөхөд сэлт; бэлэг сэлт; мэдээ сэлтийг хүргүүлэв.*

СЭЛТРЭХ ховхрох, хуурах, холтрох.

СЭЛТЭР: сэлтэр салтар яаруу, сандруу, санд мэнд.

СЭЛҮҮЛЭХ сэлэхийн үйлдүүлэх хэв.

СЭЛҮҮН чөлөө зайтай, нам тайван; *энэ өдөр ажил сэлүүн байна; нохой муу сайн юм сэлүүн сайхан байв.*

СЭЛҮҮР онгоц сал зэргийг усан дотор залж явуулахад хэрэглэх хэрэглэл, сэлбүүр; *онгоцны сэлүүр.*

СЭЛҮҮРДҮҮЛЭХ сэлүүрдэхийн үйлдүүлэх хэв.

СЭЛҮҮРДЭХ сэлүүрээр хөдөлгөх, явуулах; *онгоц сэлүүрдэх.*

СЭЛҮҮРЧ сэлэхдээ чадамгай хүн.

СЭЛҮҮХЭН нилээд сэлүүн.

СЭЛҮҮЦЭХ сэлгэцэх.

СЭЛХРЭХ хүний нүүр биед бага зэрэг хаван суух; *нүүр сэлхрэх.*

СЭЛХРЭЭ сэлхэрсэн нь; *нүдний сэлхрээ арилахгүй болжээ.*

СЭЛЭГ: бэлэг сэлэг бэлэг сэлт, бэлэг юм.

СЭЛГЭЦ а м ь т а н өтөгтэй адил болоод арай бага, заан мэт хамартай, арслан мэт толгойтой, хар цагаан холимог бидэртэй нэгэн зүйл амьтан, усанд чадамгай сэлнэ.

СЭЛЭМ (СЭЛМЭН) байлдааны хэрэглэх, том хутга адил зэвсэг; *сэлмээр цавчих; сэлэмний хуй; сэлэм жад адгийн зэвсэг, сэцэн ухаан дээдийн зэвсэг* з үй р; **сэлмэн эвэр** (урагш хандсан, хурц үзүүртэй урт эвэр).

СЭЛЭМДЭХ сэлмээр цавчих, дүрэх; *бургас сэлэмдэх.*

СЭЛЭХ I 1. онгоц сал зэргийг сэлүүрээр залах; *онгоц сэлэх; завь сэлэх;* 2. хүн амьтны усанд орж гар хөлөөр самчин залан явах; *усанд сэлэх.*

СЭЛЭХ II солих, халах, халах сэлэх; **солих сэлэх** х о р ш.; *хувцас сэлэх; нутаг сэлэх; сэлж унах морьтой хүн.*

СЭЛЭЭ халаа, солио; **халаа сэлээ, сэлээ солио** х о р ш..

СЭМ 1. сэмээр, аяархан; *сэм ярих; сэм орж ирэх; сэм чагнах; сэм отох; сэм өгөх; сэм шоолох; сэм бол гэм, гэм бол зэм* з үй р; 2. нам, дугуй, битүүхэн; *сэм хуйвалдах; сэм суух.*

СЭМБИЙЛГЭХ сэмбийхийн үйлдүүлэх хэв.

СЭМБИЙХ сэмбэгэр болох.

СЭМБЭГНҮҮЛЭХ сэмбэгнэхийн үйлдүүлэх хэв.

СЭМБЭГНЭХ сэмбэгэр юмны сэмбэг сэмбэг хөдлөх.

СЭМБЭГЭР 1. сэвсгэр, хөвсгөр байдалтай юм; 2. хүний зан байдал цэмцгэр.

СЭМБЭГЭРХЭН 1. арай сэмбэгэр, баахан сэмбэгэр; 2. цэмцгэрхэн.

СЭМБЭЛЗЭХ сэмбэгэр юмны сэмбэс сэмбэс хөдлөх.

СЭМГЭР нимгэн, сийрэг байдалтай юм; *сэмгэр үүл сэмгэр даавуу.*

СЭМЖ (ИН) амьтны гэдэс ходоод зэргийг бүрж байх нимгэн өөх; *сэмжинд ороосон илэг шарж иднэ;* **сэмжин үүл** (агаарт байгаа нь сэмж мэт нимгэн сиймгэр харагдах нэг зүйлийн үүл).

СЭМЖЛЭХ 1. сэмж сайтай болох; 2. өөхөлж таргалах.

СЭМЛҮҮЛЭХ сэмлэхийн үйлдүүлэх хэв

СЭМЛЭХ эд бөс ноос зэргийн юмыг удран ширхэг авах буюу задархай болгох; *утас сэмлэх; ноос сэмлэх.*

СЭМРҮҮЛЭХ сэмрэхийн үйлдүүлэх хэв.

СЭМРЭХ торго бөс зэрэг юм элж ширхэг алдран цуврах; *дээлийн хормой сэмэрчив; сэмэрч урагдах.*

СЭМТГЭР эмтгэр; **эмтгэр сэмтгэр** х о р ш..

СЭМТИЙХ юмны эмтгэр сэмтгэр болох.

СЭМТРЭХ эмтрэх, сэлтрэх.

СЭМХЭН нилээд сэм, баахан сэм; *сэмхэн ирэх хулгайчийн арга, сэргэмжлэн манах манаачийн үүрэг* з ү й р.

СЭМЧИХ үс ноос зэргийг байн байн сэмлэх.

СЭМЧҮҮЛЭХ сэмчихийн үйлдүүлэх хэв.

СЭМЭРХИЙ эд бөсийн ширхэг алдран элэгдэж урагдсаны нь; *сэтэрхий зүүнээс, сэмэрхий хадагнаас худалдав* (оньсго худалдахад хэлэх үг).

СЭМЭРХИЙДЭХ хэтэрхий сэмэрхий болох

СЭМЭЭР бүсдад мэдэгдэхгүй нууцаар гэсэн санаа; *дайсныг сэмээр сурвалжлах; хэргийг сэмээр дарагдуулах; сэмээр хэлэлцэх; сэмээр хуйвалдах.*

СЭМЭЭРХЭН баахан сэмээр; *сэмээрхэн босоод хувцсаа өмсч гарав.*

СЭНГЭНҮҮЛЭХ сэнгэнэхийн үйлдүүлэх хэв.

СЭНГЭНЭХ 1. сэрүүн салхи салхилах; *салхи сэнгэнэж байна;* 2. тааламжтай сайхан үнэр анхилан үнэртэх; *сэнгэнэсэн сайхан үнэртэй;* 3. хамарт хүйтэн сэрүүн оргих шиг болох; *хамар сэнгэнэх.*

СЭНДИЙЛҮҮЛЭХ сэндийлэхийн үйлдүүлэх хэв.

СЭНДИЙЛЭХ газрыг ихэд ухаж хөндийлөх; *доогуур нь сэндийлэх.*

СЭНДЛҮҮЛЭХ сэндлэхийн үйлдүүлэх хэв.

СЭНДЛЭХ 1. газрыг ухаж сэндийлэх; 2. ургаа юмыг ховхлон булгалах.

СЭНДЧИХ байн байн сэндлэх.

СЭНДЧҮҮЛЭХ сэндчихийн үйлдүүлэх хэв.

СЭНДЭН у р г а м а л халуун орчинд ургадаг нэгэн зүйл зандан мод, сэрүүн чанартай бөгөөд үнэр сайхан, хүж хийвэл маш сайхан үнэртэй.

СЭНЖ 1. юманд барих, өргөх, хэлхэх, уях зэрэгт зориулан хийсэн юм; *авдрын сэнж; хувингийн сэнж; дөрөөний сэнж; товчны сэнж;* **сэнж бариул** х о р ш.; **сэнжтэй аяга** (бариул бүхий аяга); 2. утас зэрэг юмыг нэгэн ширхгээр багасгаж эвхсэн хэсэг; *нэг сэнж утас.*

СЭНЖГЭР санжгар, унжгар.

СЭНЖИГНҮҮЛЭХ сэнжигнэхийн үйлдүүлэх хэв.

СЭНЖИГНЭХ санжганах.

СЭНЖИД тамга тэмдгийн бариул.

СЭНЖЛҮҮЛЭХ сэнжлэхийн үйлдүүлэх хэв.

СЭНЖЛЭХ юманд барих сэнжтэй болгох, сэнж гаргах; *хувин сэнжлэх; мах сэнжилж өлгөх;* **нохой сэнжлэх** (нохой лав нэвт хазах).

СЭНС I хэд хэдэн далбаа бүхий эргэх хэрэгсэл; *усны сэнс; онгоцны сэнс.*

СЭНС II сэгсүүрэг арьс; *сэнс арьс.*

СЭНСЛҮҮЛЭХ сэнслэхийн үйлдүүлэх хэв; *дүгуйгаа сэнслүүлсэн байна.*

СЭНСЛЭХ сэнс болгох, сэнстэй болох, муруйх, тахийх; *дугуй минь сэнсэллээ.*

СЭНСРЭХ сэнс болох, сэнстэй болох; *дугуйны хэгээс сэнсрэх.*

СЭНСТЭЙ сэнс бүхий; **сэнстэй чарга** (нисэх тэрэгний хөдлөгүүртэй сэнс бүхий чарга); **сэнстэй худаг** (салхины хүчээр хөдлөх сэнс бүхий худаг).

СЭНХРҮҮЛЭХ бусдад юмны учир зүйг тодорхойлон мэдрүүлж ухуулах; *ухуулах сэнхрүүлэх; сэнхрүүлэн мэдрүүлэх.*

СЭНХРЭХ юмны учир зүйг ойлгож мэдэх, ухаарах.

СЭР: сэр сэр салхилах чимээ; *сэр сэр салхилах; сэр сэр бороо хувцас барна, шивэр авир үг ая барна* з үйр.

СЭРВИЙЛГЭХ сэрвийхийн үйлдүүлэх хэв, сэрэвгэр болгох.

СЭРВИЙХ 1. сэрэвгэр болох; 2. өвдсөн хүний бага зэрэг ялаарь болох; **сэхэх сэрвийх** х о р ш.; *би саянаас сэрвийж байна.*

СЭРВЭГНҮҮР түргэн зан ааштай; *сүрхий сэрвэгнүүр хүн шүү.*

СЭРВЭГНҮҮЛЭХ сэрвэгнэхийн үйлдүүлэх хэв.

СЭРВЭГНЭХ 1. үс өвс зэргийн салхинд хөдлөх; *үс сэрвэгнэх; өвсний толгой сэрвэгнэж байна;* 2. салхи баахан салхилах; *салхи сэрвэгнэ;* 3. амьтны ааль зан нэгэн аяс биш болох; *сэрвэгнэсэн хачин зантай хүн;* 4. сэрэвгэр юмны сэрвэг сэрвэг хөдлөх.

СЭРВЭЛЗЭХ сэрэвгэр юмны сэрвэс сэрвэс хөдлөх.

СЭРВЭН тэгшгүй сэрэвгэр сэртгэр юм; *сэрвэн хад.*

СЭРВЭСХИЙХ 1. юмны гэнэт сэрвийж үзэгдэх; 2. сэрсхийх.

СЭРВЭЭ 1. амьтны сээрний дээд этгээд товгорхон газар; 2. усны амьтдын нуруу хавийн сэлэх эрхтэн; *загасны сэрвээ;* 3. сэрвэн.

СЭРГИЙЛҮҮЛЭХ сэргийлэхийн үйлдүүлэх хэв.

СЭРГИЙЛЭГЧ сэргийлэх албан үүрэг гүйцэтгэгч; *манай сэргийлэгчид.*

СЭРГИЙЛЭХ юмыг болгоомжлон сахих харгалзах; **сахих сэргийлэх** х о р ш.; *манаж сэргийлэх; урьдчилан сэргийлэх; хил хязгаарыг сэргийлэх; эмчлэн сэргийлэх;* **цагдан сэргийлэх** (Бүгд Найрамдах Монгол Ард Улсад нийгмийн хэв журам, аюулгүй байдал, улсын болон иргэдийн хувийн өмчийг хамгаалах албан газар).

СЭРГЭВЭЛЗЭХ хүн амьтны еэгүй зан царай гаргах, сэрвэлзэх ч гэнэ.

СЭРГЭГ 1. үйл яьдалд сэхээтэй, сэргэлэн; **сэргэг соргог** х о р ш.; 2. **нойр** багатай, хялбар сэрдэг; *сэргэг хүүхэд.*

СЭРГЭЛЗЭХ сэргэвэлзэх.

СЭРГЭЛЭН 1. амьтны цовоо чадамгай; **сэргэлэн цовоо** х о р ш.; 2. саруул сайхан.

СЭРГЭЛЭНДЭХ хэтэрхий сэргэлэн болох.

СЭРГЭМЖ хянамж, болгоомж, сэрэмж ч гэдэг; **сонор сэрэмж** х о р ш..

СЭРГЭМЖЛҮҮЛЭХ сэргэмжлэхийн үйлдүүлэх хэв.

СЭРГЭМЖЛЭХ юманд сэргэмжтэй байх, сэрэмжлэх.

СЭРГЭР саргар, дэргэр; *сэргэр эвэртэй үхэр; сэргэр үзүүртэй мод.*

СЭРГЭХ 1. дордож доройтсон байдлаас сэхэж дээрдэх, дээшлэх; *нүд сэргэх; сэтгэл сэргэх; сэргэж яваа айл; ажил нь сэргэх; ногоо сэргэх;* 2. унтсан амьтны нойр ханаж сэрэх; *нойр сэргэх;* 3. мартагдсан удсан хэрэг явдал дахин үүдэн гарах; *хэрэг сэргэх;* 4. үхэтгэн унасан буюу согтсон хүн амьтны ухаан мэдрэл орох, сэхэх; *муурч унаад сэргэх.*

СЭРГЭЭХ сэргэхийн үйлдүүлэх хэв; *нойры нь сэргээх; мартагдсаныг сэргээх; уйтгар сэргээх; аж ахуйгаа сэргээх; толгойгоо сэргээх; согтуу хүнийг сэргээх.*

СЭРДҮҮЛЭХ 1. сэрдэхийн үйлдүүлэх хэв; 2. сэрдэгдэх.

СЭРДХИЙХ хэлмэж хирдхийх; *дотор сэрдхийгээд бие аягүй болов.*

СЭРДЭГДЭХ сэрдэхийн үйлдэгдэх хэв.

СЭРДЭХ хардах, сэжиглэх; **хардах сэрдэх** х о р ш.; *хулгайд сэрдэх.*

СЭРЖГЭР саржгар, дэржгэр.

СЭРЖИГНҮҮЛЭХ сэржигнэхийн үйлдүүлэх хэв.

СЭРЖИГНҮҮР 1. хөнгөн хийсвэр; *сэржигнүүр зантай хүн;* 2. намуухан салхи; *сэржигнүүр салхи.*

СЭРЖИГНЭХ 1. салхины зөөлөн салхилах; *салхи сэржигнэх;* 2. цаас зэрэг нимгэн юмны салхинд үлээгдэн дуугарах.

СЭРЖИЙЛГЭХ сэржийхийн үйлдүүлэх хэв.

СЭРЖИЙХ сэржгэр болох.

СЭРИЙЛГЭХ сэрийхийн үйлдүүлэх хэв.

СЭРИЙХ сэргэр болох; *эвэр нь сэрийгээд суртэй харагдана.*

СЭРЛЭГ сургар. •

СЭРМЭХ 1. юмны зах ба өө сэвийг дарж авах; 2. нялх малын анх өвс идэж эхлэх; *өвс сэрмэх;* 3. өвсний толгойг мал шүүрдэн идэшлэх; *билчээр сэрмэх.*

СЭРСХИЙХ айсан сочсон зэргээс бие зарсхийх, арзасхийх; *дотор сэрсхийв; бие сэрсхийгээд явчив.*

СЭРТВЭЛЗЭХ 1. амьтны ийш тийш сэлбэлзэн харах; 2. хүний аалигүй зан байдал гаргах.

СЭРТГЭР сээтэн, сэртэн хэлбэртэй юм; *сэртгэр эвэр; сэртгэр чих.*

СЭРТИЙЛГЭХ сэртийхийн үйлдүүлэх хэв, сэртгэр болгох.

СЭРТИЙХ сэртгэр болох; *чих нь сэртийж харагдав.*

СЭРТЭВХИЙХ морь малын чих байн байн хөдлөх, сочсон байдал гаргах.

СЭРТЭГНҮҮЛЭХ сэртэгнэхийн үйлдүүлэх хэв.

СЭРТЭГНЭХ 1. мал гөрөөсний зэрэг амьтны чих байн байн сэртэлзэн хөдлөх; 2. сэртгэр юмны сэртэг сэртэг хөдлөх; 3. зэрэмгэнэх, дэрэмгэнэх.

СЭРТЭЛЗҮҮЛЭХ сэртэлзэхийн үйлдүүлэх хэв.

СЭРТЭЛЗЭХ сэртгэр юмны сэртэс сэртэс хөдлөх.

СЭРТЭН I. сэртгэр юм; *босоо сэртэн, хөндлөн сэртэн;* 2. сэртэгнэх нь; *сэртэн сэртэн хийх.*

СЭРТЭНДҮҮЛЭХ сэртэндэхийн үйлдүүлэх хэв.

СЭРТЭНДЭХ хүний бусдад тачааж элдэв ааль зан гаргаж халан өдөөх.

СЭРҮҮ сэрүүн; *сэрүү орж байна; сэрүү татах; сэрүү оргих.*

СЭРҮҮВТЭР баахан сэрүүн.

СЭРҮҮДҮҮЛЭХ сэрүүдэхийн үйлдүүлэх хэв.

СЭРҮҮДЭХ хэтэрхий сэрүүн болох.

СЭРҮҮЛЭГ цагны хонх зэргийн нойроос сэрээхэд зориулсан зүйл; *сэрүүлэгтэй цаг.*

СЭРҮҮЛЭХ сэрэхийн үйлдүүлэх хэв, сэрээх.

СЭРҮҮН I баахан жихүүн, хүйтэвтэр; **хүйтэн сэрүүн** хорш.; **сэрүүн бүлээн** (зөөг бүлээн); **сэрүүн цэцэг** ургамал (хотгор газар ургана, иш салаа хөндий, дурс улаан, цэцэг цагаан, тоорцог шар нэг зүйл цэцэг); **сэрүүн асар** (сэрүүцэн суухад зориулан хийсэн хөнгөн маягийн байшин).

СЭРҮҮН II хүн амьтны унтаагүй; *орой болтол унталгүй сэрүүн хэвтэв.*

СЭРҮҮТЭХ улам сэрүүн болох.

СЭРҮҮХЭН нилээд сэрүүн.

СЭРҮҮЦҮҮЛЭХ сэрүүцэхийн үйлдүүлэх хэв.

СЭРҮҮЦЭХ хүн амьтны бие халж халууцахаас ангижирч сэрүүн болох.

СЭРХ гурван наснаас дээших агталсан эр ямаа.

СЭРХГЭР сэргэг.

СЭРХИЙЛГЭХ сэрхийхийн үйлдүүлэх хэв. •

СЭРХИЙХ 1. сэртийх; 2. сэрдхийх; *сочиж бие сэрхийх;* 3. сэр гэсэн чимээ гэнэт гарах. •

СЭРХЛЭГ ургамал толгод, уулын энгэр газрын аса хайргатай хөрсөнд ургадаг бамбайн төрлийн ургамал, цэцэг шар, зарим сэрхлэгийн үндэс нь бамбайн үндэстэй адил, эмнэлэгт хэрэглэнэ.

СЭРХНЭД бага хүүхдийн биед гарах бодоогийн адил боловч өтгөн цадуухгүй, хаажтахгүй нэгэн зүйл өвчин.

СЭРШ I сэрэхүй чанар.

СЭРШ II нэгэн зүйлийн богино хадаг, намгар ч гэнэ.

СЭРШГҮЙ 1. сэрэх шинжгүй; *сэршгүйгээр унтаж байна;* 2. санашгүй; *санаж сэршгүй юманд сэвэх хэрэггүй.*

СЭРЭВГЭР сэрвэн, сэргэр; *сэрэвгэр хад; сэрэвгэр мод; сэрэвгэр үс.*

СЭРЭГДЭХ 1. сэрэхийн үйлдэгдэх хэв; 2. хүний гэмт явдал сэдэвлэгдэх; *хулгайд сэрэгдэх;* 3. мэдрэлийн эрхтэнд мэдрэгдэх.

СЭРЭГДЭХҮҮН сэрэгдэж байгаа юм.

СЭРЭМЖ хянамж, болгоомж, сэргэмж; *сонор сэрэмж; улс төрийн сонор сэрэмж.*

СЭРЭМЖГҮЙ хянамж болгоомжгүй, сэргэмжгүй; *сэрэмжгүй байснаас ийм хэрэг болов.*

СЭРЭМЖЛҮҮЛЭХ сэрэмжлэхийн үйлдүүлэх хэв, сэргэмжлүүлэх.

СЭРЭМЖЛЭХ үйл явдалд хянамж болгоомж сэрэмжтэй байх, сэргэмжлэх.

СЭРЭМЖТЭЙ сэрэмж, болгоомж сайтай, сэргэмжтэй.

СЭРЭХ I 1. нойроос сэрэх; *унтсанаа сэрэх, мартсанаа санах* з үй р; 2. сэрэмжлэх, болгоомжлох; **сэрэх бодох, сэрэх сэрэмжлэх** х о р ш.; 3. мэдрэх, сэрэгдэх: **сэрэхүй мэдрэл.**

СЭРЭХ II бусдыг хардах, сэжигдэх, сэрдэх, сэжиглэх; *хулгайд сэрэх; хэрэгт сэрэх.*

СЭРЭХҮЙ урьдаас туулан мэдэх мэдлэг, мэдрэхүй.

СЭРЭЭ 1. хоол зэрэг юмыг өлгөж авах 2, 3, 4 шүдтэй төмөрлөг буюу модоор хийсэн хэрэглэл; 2. юмыг хатгах бүлэхэд зориулсан 2, 3 шүдтэй зэвсэг; 3. өвсний ац.

СЭРЭЭДҮҮЛЭХ сэрээдэхийн үйлдүүлэх хэв.

СЭРЭЭДЭХ сэрээгээр өлгөх, чичих.

СЭРЭЭЛГЭХ сэрээхийн үйлдүүлэх хэв; хүнээр сэрээлгэхийн хэрэггүй өөрөө л босох *ёстой юм.*

СЭРЭЭЛЖ жимс түүх сэрээ.

СЭРЭЭХ сэрээхийн үйлдүүлэх хэв; *намайг чи сэрээгээрэй.*

СЭТ хүч нэмэгдүүлэх үг; *сэт цохих; сэт малтах; сэт оглох; сэт татах.*

СЭТГҮҮЛ ямар нэгэн асуудлын утга учир, чанар байдал зэргийг олон нийтэд таниулахын тул зориулж тогтмол тараах хэвлэл бичиг; **сонин сэтгүүл** х о р ш.; *«Шинжлэх ухаан» сэтгүүл; сэтгүүлийн тойм;* 2. цаг үеийн байдлыг гаргах богино хэмжээний баримтат кино; *кино сэтгүүл.*

СЭТГҮҮЛЭХ сэтгэхийн үйлдүүлэх хэв.

СЭТГҮҮР сэтгэх хэрэгсэл; *гансны сэтгүүр, соёо сэтгүүр.*

СЭТГЭГДЭЛ сэтгэсэн, сэтгэгдсэн юм; *сайхан сэтгэгдэл төрөв; сэтгэгдэл муухантай байх шиг байна.*

СЭТГЭГДЭХ сэтгэхийн үйлдэгдэх хэв, санагдах, бодогдох.

СЭТГЭГДЭХҮҮН сэтгэлд сэрэгдсэн, сэтгэгдсэн зүйл.

СЭТГЭГЧ гүн ухаан зэргийн аливаа юмыг сэтгэлдээ нотод тогтоон бодогч.

СЭТГЭЛ элдвийг сэтгэх ухааны эрхний нь: санаа, бодол, дур, хүсэл; **санаа сэтгэл, бодол сэтгэл, дур сэтгэл, хүсэл сэтгэл** х о р ш.; *сэтгэл гэмтний санаа амаргүй* з үй р; **сэтгэл тэжээх** (санааг хөгжөөх); **сэтгэл алгасах** (санаа самуурах, бодлогошрол мартагнах); **сэтгэл үймрэх** (сэтгэл сарнин үймчих); **сэтгэл тэнүүн** (санаа амар); **сэтгэл ханах** (хүсэл дур хангагдах); **сэтгэл хувиарлах** (сэтгэл хоёрдох, хоёр тийш бодох); **сэтгэл хоёрдох** (сэтгэл хоёрын хооронд хувиарлагдан тээнэгэлзэх); **сэтгэл хөдлөх** (сэтгэл хөхөн хөгжих); **сэтгэл уярах** (өрөвдөх сэтгэл төрөх); **сэтгэл зөөлрөх** (сэтгэл уярах); **сэтгэл төөрөх** (сэтгэл санаа үймрэх, самуурах); **сэтгэл татах** (эрхгүй дурлах байдал төрөх); **сэтгэл зовох** (сэтгэл санаа зовних); **сэтгэл булаах** (сэтгэлд эрхгүй дурламаар санагдах); **цагаан сэтгэл** (хар хоргүй, тусчихан сайхан сэтгэл); **хар сэтгэл** (хорлол хөнөөлтэй сэтгэл); **буруу сэтгэл** (хүний ёс зүйд нийцэхгүй санаа бодлоготой); **хорт сэтгэл** (хорт санаа); **зөв сэтгэл** (хүний ёс зүйд нийцэж зохицсон санаа бодлоготой); **үнэн сэтгэл, чин сэтгэл** (хоёргүй сэтгэл); **халуун сэтгэл** (дотно сэтгэл); **сэтгэл хангалуун** (сэтгэл түвшин тавиун); **нинжин сэтгэл** (маш өрөвч сэтгэл); **энэрэнгүй сэтгэл** (өршөөн хайрлах сэтгэл); **хайр сэтгэл** (дурлал хайр); **янаг сэтгэл** (хайр дурлал); **хатуу сэтгэл** (энэрэл хайргүй сэтгэл); **зөөлөн сэтгэл** (өрөвч уяхан сэтгэл); **сэтгэл дурнаа зохистой** (үнэхээр сэтгэл булаахаар юм); **сэтгэлийн хөдөлгөөн** (сэтгэлийн хөгжөөн); **сэтгэлийн зовлон** (сэтгэлийн гансрал, гутрал); **сэтгэлийн сэв** (сэтгэлийн зэвүүцэл); **сэтгэлийн бузар** (сэтгэлийн жигшил, зэвүүцэл); **сэтгэлийн бахдал** (санааны бахархал); **сэтгэлийн өвчин** (санаа ширч бодлогоширсон өвчин; *сэтгэлийн өвчнийг үгээр, биеийн өвчнийг эмээр* з үй р); **сэтгэлд гөмсдөх** (сэтгэлд хангалттай биш са-

нагдах); **сэтгэлд дотно** (аятай санагдах нь); **сэтгэлд хүрэхгүй** (санасанд хүрэхгүй); **сэтгэл мэдэхгүй** (санасанд хүрэхгүй); **сэтгэлд орох** (сананд санагдах); **сэтгэлд хадах** (сананд үхшрэх); **сэтгэл нийцэх** (сананд таарах, зохицох); **нэг сэтгэлээр** (нэг санаагаар); **сэтгэлтэй болох** (хайртай, дуртай болох); **сэтгэл судлал** (сэтгэхүйн процесс, сэтгэхүйн үйл ажиллагааны зүй тогтоолыг судлах ухаан); **сэтгэл судлаач** (сэтгэл судлалд мэрэгжсэн хүн).

СЭТГЭЛГЭЭ сэтгэлэг.

СЭТГЭЛЧЛЭН санасан хүссэн ёсоор, санасанчлан; *санасан хэрэг чинь сэтгэлчлэн бүтэх болтугай!* (ерөөлөөс).

СЭТГЭЛЭГ хүний төрлөх чанараас гарч ирэх санаа.

СЭТГЭХ I хүний онцгой чанар болох бодох, тунгаан бодох; **сэрэх сэтгэх, бодох сэтгэх** х о р ш.; *сэтгээж суух.*

СЭТГЭХ II бөглөрсөн нүх сүв мэтийг сэтгүүрээр ухаж хатгах; *ганс сэтгэх.*

СЭТГЭХҮЙ хүний онцгой чанар болох бодох, тунгаан бодох чадвар.

СЭТГЭШГҮЙ хүний санаанд бодвол үл олох зүйл.

СЭТЛЭХ сэтрэхийн үйлдүүлэх хэв, сэтэрхий болгох; *ирмэгийг сэтлэх; сувгийн эргийг сэтлэх; сэтлэн нийлүүлэх; ус даланган сэтлэх; дайсны хориглолтын шугамыг сэтлэх.*

СЭТРЭХ юмны сэтэрхий болох ба сэлтрэх; *шаазангийн ам сэтрэх; зүүний сүвэгч сэтрэх.*

СЭТЭР шашны ёсонд: малыг бурхан сахиусанд өргөв гэж хадаг хив уяж, эдлэхгүй болгон дархлах; **сэтэр зүүх** (хоосон нэр зүүх).

СЭТЭРЛҮҮЛЭХ 1. сэтэрлэхийн үйлдүүлэх хэв; 2. сэтэрлэгдэх.

СЭТЭРЛЭГДЭХ сэтэрлэхийн үйлдэгдэх хэв.

СЭТЭРЛЭХ сэтэр зүүх.

СЭТЭРХИЙ 1. эмтэрсэн, сэтэрсэн, зах ирмэг нь гэмтсэн, эмтэрсэн нь; *сэтэрхий шаазан;* 2. уруул хамар зэрэг эрхтэн бүтэн биш, сэтэрсэн; *сэтэрхий уруул;* 3. оньтой, хотгортой; *уулын сэтэрхийгээр даван оров.*

СЭХ сэхээ.

СЭХЛҮҮН барагтай юм тоохгүй санаатай, сэхүүн; *яасан сэхлүүн санаатай нөхөр вэ.*

СЭХРҮҮЛЭХ сэхрэхийн үйлдүүлэх хэв, мэдрүүлэх, ойлгуулах, сэнхрүүлэх.

СЭХРЭСХИЙХ баахан сэхрэх.

СЭХРЭХ сэхэх, сэргэх, дээрдэх.

СЭХҮЙХ 1. сахуйх; *сахал үс нь сэхүйсэн сүрхий царайтай амьтан харагдав;* 2. сэрвийх; *сэхүйсэн өндөр хад; тэр толгой дээр нэг хүн сэхүйн зогсч байна.*

СЭХҮҮН сэхлүүн, сэгэл санаатай.

СЭХЭХ 1. дорой буурай байдал дээшлэх; засрах, сайжирч эхлэх; *сэхэн засарч яваа аж ахуй; эр хүн долоо дордож найм сэхэх* з ү й р; 2. муужирч унасан хүн амьтан дахин ухаан орох; *муужирч унаад сэхэх;* 3. өвчин эдгэрч бие засрах төлөвийг олох; *хөгшин сэхжээ.*

СЭХЭЭ 1. ухвар; **сэхээ муутай** (ухвар буурай); **сэхээ авах** (санаа авах); **сэхээ орох** (сая ухварлах); **сэхээ ухаагүй** (сэхээгүй); 2. самбаа, сэх, заль; **самбаа сэхээ** х о р ш.

СЭХЭЭВЧ орон савын дотоодыг саруул, гэрэл сайтай болгоход зориулсан өндөр том цонх.

СЭХЭЭГҮЙ 1. ухваргүй; 2. арга залигүй.

СЭХЭЭРҮҮЛЭХ сэхээрэхийн үйлдүүлэх хэв.

СЭХЭЭРЭХ 1. сэхээ орох; 2. ухварлах, ойлгох.

СЭХЭЭТЭН шинжлэх ухаан, техник, соёлын талаар эрдэм боловсрол, тусгай мэдлэг бүхий оюуны хөдөлмөрийн хүмүүс; *Монголын ард түмний сэхээтэн нар; хөрөнгөтний сэхээтэн; оюутан сэхээтэн.*

СЭХЭЭХ сэхэхийн үйлдүүлэх хэв, сэхэхэд хүрүүлэх.

СЭЦЭН цэцэн, мэргэн; **сэцэн өвс** у р г а м а л (хад ба ваар дээвэртэй барилга дээр ургадаг, самрын боргоцоотой төстэй ногоо).

СЭЦЭРХҮҮ сэцэрхэх дуртай, сэцэрхэх зантай, цэцэрхүү.

СЭЦЭРХЭХ цэцэрхэх.

СЭЧИГ зарим шувуу ба хэвлээр явагчны толгой дээр ургах зүйл; *тахианы сэчиг.*

СЭЭР хүзүүний үе харцгын үе хоёрын хооронд байх бөгөөд хавирганы бураа залгалдан өрших, нурууны арван хоёр үе яс; *нуруу сээрээрээ нугалуулсан тахиа* (бадарчны үлгэ-

рээс); **сээр нуруутан** (хөвчтөн амьтны салбар хүрээнд багтах толгой, их бие, сүүл бүхий амьтад); **сээрэн дунгуй** (нурууны дээгүүрээ дамнуулан хаях бөхийн мэх).

СЭЭРДҮҮ зан дээгүүр, дээрэнгүй.

СЭЭРДЭХ дээрэнгүй, дээгүүр зан гаргах.

СЭЭТГЭР 1. аалигүй, сээтэгнүүр; 2. дээгүүр зантай; 3. сээтэн.

СЭЭТГЭГНҮҮЛЭХ сээтэгнэхийн үйлдүүлэх хэв.

СЭЭТЭГНҮҮР аалигүй, сэртэгнүүр зан байдалтай; *сээтэгнүүр хүүхэн.*

СЭЭТЭГНЭХ сээтэгнүүр зан байдал гаргах.

СЭЭТЭЛЗЭХ сээтгэр юмны байн байн хөдлөх.

СЭЭТЭН 1. соотон; *сээтэн чихтэй;* 2. сээтэгнүүр.

СЭЭХГЭР сээтгэр.

СЭЭХЭЛЗҮҮР хөнгөн сээтэгнүүр.

СЭЭХЭЛЗЭХ 1. сээхгэр зан байдал гаргах; 2. сээтэлзэх.

Т

Т т үсэг, т авиа.

ТА бусдыг хүндэтгэн дуудахад хэрэглэх хоёрдугаар биений төлөөний үг; *та энд суугтун! та сайн байна уу? та таваараа байгтун! та хоёр; та бүхэн.*

ТААВААР өөрийн дураар, биедээ таалалтайгаар, тавтай; *таваараа амарч өнжөөд яв! аав таваараа гэлдэрч айгуй! таваараа бай!*

ТААВАР 1. тааварлах нь, тааж байгаа юм; *тэр бол зөвхөн таавар;* 2. сэжиг; **сэжиг таавар** хорш.; 3. оньсго; *таавар таацгаах уу?*

ТААВАРЛАХ 1. тийм болов уу гэх, бодлоор тааруулах; *магад хүрсэн гэж тааварлаж байна; сайн мэдэхгүй бол тааварлах хэрэггүй;* 2. эргэлзэн сэжиглэх; *сэжиглэх тааварлахын хэрэг алга.*

ТААВАРЛУУЛАХ тааварлахын үйлдүүлэх хэв.

ТААГҮЙ I 1. тавгүй, тухгүй, тохигүй; 2. тааламжгүй.

ТААГҮЙ II дургүй, таалалгүй.

ТААДАЙЛГАХ таадайхын үйлдүүлэх хэв.

ТААДАЙХ таадгар болох.

ТААДАЛЗАХ таадгар юмны таадас таадас хөдлөх.

ТААДАС: таадас таадас хийх таадгар юмны байн байн хөдлөх.

ТААДГА: таадга таадга хийх таадгар юмны үргэлжлэн хөдлөх.

ТААДГАНАХ таадгар юмны таадга таадга хөдлөх.

ТААДГАР богино, тагдгар.

ТААЗ адар, байшингийн дотоод дээвэр болох хэсэг; *тааз шохойдох; таазны туйпуу;* **таазны хөндий** (дээвэр тааз хоёрын хоорондох хөндий).

ТААЗЛАХ тааз хийх; *байшин таазлах.*

ТААЗЛУУЛАХ таазлахын үйлдүүлэх хэв.

ТААЛАГДАХ таалахын үйлдэгдэх хэв.

ТААЛАЛ хүндэтгэвэл зохих хүний дур, санаа; *таалалд нь нийлүүлэх; таалал гажих; тогтоосон таалал;* **таалал төгсөх** (үхэхийн хүндэтгэл).

ТААЛАМЖ нийлэмж, нийцэмж, зохимж; *тэд нарын тааламж муухан байна билээ.*

ТААЛАМЖГҮЙ сэтгэл дурнаа зохисгүй; *тааламжгүй үйл хийсэндээ гэмшинэ; тааламжгүй үнэр.*

ТААЛАМЖЛАХ таалах.

ТААЛАМЖЛУУЛАХ 1. тааламжлахын үйлдүүлэх хэв; 2. таалуулах.

ТААЛАМЖТАЙ сэтгэл дурнаа зохистой; *тааламжтай салхи; тааламжтай үнэр; тааламжтай хоол; тааламжтай байдал; сэтгэлд тааламжтай сайхан санагдав.*

ТААЛАХ 1. ойшоох, сэтгэлд зохилдох, дурлах; *ойшоон тааллах; дурлан тааллах;* 2. озох, үнсэх; *үнсч тааллах.*

ТААЛГА таавар; **таавар таалга** х о р ш..

ТААЛГАХ таахын үйлдүүлэх хэв; *юм таалгах.*

ТААЛСХИЙХ баахан таалах.

ТААЛУУЛАХ 1. таалахын үйлдүүлэх хэв; 2. таалагдах.

ТААЛЦАХ таахын хамтран үйлдэлцэх хэв; *оньсго таалцах; шагаа таалцах.*

ТААМ таавар.

ТААМААРАА тааваараа, эрх дураараа.

ТААМАГ 1. таавар, тойм; *таамгаар хэлэх; таамгаар хийх; таамгаар явах;* 2. сэжиг; **сэжиг таамаг** х о р ш.: *таамаг сэжиг ихэдвэл танил нөхдөөсөө хагацна* з ү й р.

ТААМАГЛАЛ таамнал.

ТААМАГЛАХ 1. тааварлах, тийм байх гэх; *бид нүдээр үзээгүй, харин таамаглаж байна; таамаглан зурах;* 2. сэжиглэн санах.

ТААМАГЛУУЛАХ таамаглахын үйлдүүлэх хэв.

ТААМНАЛ тааварлах нь, таавар, таамнах үйлийн нэр.

ТААМНАХ тааварлах, тааж бодох.

ТААНА у р г а м а л хээр, говийн бүсэнд ургадаг олон наст ургамал, цэцэг цагаан, зун орой цэцэглэнэ, өндөр нь 10—20 см. бүх төрлийн малын сайн тэжээл болно.

ТААНУУС та нар, та бүхэн.

ТААР 1. ноос олсоор бүдүүн нэхсэн нэгэн зүйл эд; *таар шуудай;* 2. бүдүүн өрмөгөөр хийсэн зүйл; *таартай ноос.*

ТААРАЛДАХ 1. таарах; 2. тохиолдох, дайралдах, онолдох; *би зах дээр ахтай тааралдав; би хэдэн удаа ирсэн, чамтай ер тааралдсангүй.*

ТААРАЛДУУЛАХ тааралдахын үйлдүүлэх хэв.

ТААРАМЖ нийлэмж, тохиромж; *таарамж сайтай гэр; таарамж муутай байна.*

ТААРАМЖГҮЙ тохиромжгүй, нийлэмжгүй, зохимжгүй; *таарамжгүй хувцас бие гутаана; таарамжгүй санал; таарамжгүй явдал.*

ТААРАМЖТАЙ зохимжтой, нийлэмжтэй, тохиромжтой; *таарамжтай хувцас; таарамжтай хоол; таарамжтай санал.*

ТААРАХ I 1. хэмжээ тохирох, нийлэх; *бараан өнгийн дээл чамд их сайхан таарах юм; энэ цоожид таарах түлхүүр; яг таарсан шаантаг;* 2. зохицох, нийцэх; *сэтгэл таарах; таарсан эр эм хоёр таван хавтсан дээр багтдаг* з ү й р; 3. ш о о д с о н болхи буурай, хангалтгүй; *үүний хэлж байгааг хараач! харин таарч даа.*

ТААРАХ II тээрэх; *гэдэс таарч аядүй болоод байна.*

ТААРАХГҮЙ зохицохгүй, нийцэхгүй, тохирохгүй; *чи ингэж байдаг чинь таарахгүй шүү.*

ТААРЛАХ таараар бүрэх, таар хүүдийд хийх.

ТААРЛУУЛАХ таарлахын үйлдүүлэх хэв.

ТААРУУ 1. тэнцүү, тохирсон; *бүдүүгүй нарийгүй тааруу мод байна;* 2. барагтайхан, муухан; *тааруу таргатай мал; тааруу амьтан.*

ТААРУУЛАХ тааралын үйлдүүлэх хэв, онолдуулах.

ТААРУУХАН 1. нилээд тааруу; 2. барагтайхан, муухан; *тааруухан ааш гаргах; тааруухан морь.*

ТААРЦАГ илэг буюу бөс өрмөгөөр хийсэн бяцхан сав;*бичгийн тааруаг.*

ТААРЦАГЛАХ таарцагт агуулах.

ТААРЦАГЛУУЛАХ таарцаглахын үйлдүүлэх хэв.

ТААСХИЙХ түр таах; *би оньсго хэлсэн чинь жаахан таасхийгээд л...*

ТААТАЙ сананд зохистой, нийлэмжтэй, эвтэй, эетэй; *яасан таатай өдөр вэ! таатай сайхан хэрэг болжээ!*

ТААХ тааварлах, таамаглах, таамнан бодох; *оньсго таах; би юу хийх гэж байна, та нар таа?*

ТААХАЙ мал адгуусны тавгийн дээд залгаа яс.

ТААХАЙЛГАХ таахайхын үйлдүүлэх хэв.

ТААХАЙХ таахгар болох.

ТААХАЛЗАХ таахгар юмны таахас таахас хөдлөх.

ТААХАС: таахас таахас хийх таахгар юмны байн байн хөдлөх.

ТААХГА: таахга таахга хийх таахгар юмны үргэлжлэн хөдлөх.

ТААХГАНАХ таахгар юмны таахга таахга хөдлөх.

ТААХГАР тагдгар, богинохон.

ТААЦАХ тэнхцэх, таарах, тохирох; **тохирох таацах, таацах тэнхцэх** х о р ш..

ТААЦУУЛАХ таацахын үйлдүүлэх хэв, таарууллах, тохируулах.

ТААШААГДАХ таашаахын үйлдэгдэх хэв, ойшоогдох.

ТААШААЛГАХ таашаахын үйлдүүлэх хэв.

ТААШААХ ойшоох, тоомсорлон үзэх, сэтгэлдээ сайшаах; *миний явдлыг их л таашааж байв.*

ТААШААХГҮЙ ойшоохгүй, тоож тоомсорлохгүй; *таашаахгүй байдал үзүүлэх.*

ТААШГҮЙ тааж боломгүй, таах нөхцөлгүй.

ТАБЛИЦ маягт, хүрд; *таблицаар гаргах; тооны таблиц.*

ТАВ (АН) I 1. дөрөв дээр нэгийг нэмсэн нь; *таван тав хорин тав;* **таван жилийн төлөвлөгөө** (улсын албан үйлдвэрийн байгууллагуудын гүйцэтгэх ажлыг таван жилээр төлөвлөсөн төлөвлөгөө); **таван хушуу** (таван үзүүртэй тэмдэг); **таван хушуу мал** (адуу, тэмээ, үхэр, хонь, ямаа); **таван цул** (зүрх, уушиг, элэг, бөөр, дэлүү); **таван эрхтэн** (сонсох чих, үзэх нүд, үнэрлэх хамар, амтлах ам, хүрэлцэх бие энэ тав); **таван хуруу шигээ мэдэх** (маш сайн мэдэх); **таван хуруу тэгшгүй** (юм бүхэн нь сайн биш; *таван хуруу тэгшгүй, хүний сэтгэл адилгүй*); **таван саваагүй** (сахлын чимхүүр, сам, чихний ухуур, шүдний шигчлүүр, хумсны цэвэрлүүрээр бүрдсэн зүүвч); **таван нүд** (хээ); **таван гишүүн** (хоёр гар, хоёр хөл, толгой); **таван махбод** (дорно зүгийн зурхайн ёсны: алтан, модон, усан, гал, шорой энэ тав бас алтны оронд төмөр гэх ёс ч бий); **таван халуун** (гаа, бивлин, поваар, чинжүү, шанц энэ тавыг найруулан хийснийг); **таван тамсаг** (сайхан дүрс, яруу дуу, сайхан үнэр, сайхан амт, машид зөөлөн); 2. сарын тавдугаар өдөр; *өнөөдөр таван.*

ТАВ II тохь, тух; *тав алдах.*

ТАВ III бах; *тав нь ханах.*

ТАВ IV гадас, хадаас, эрэг зэрэг юмны толгой түүнд барьж жийрэглэх зүйл; *хадаасны тав; шургийн тав; тав барьж хадах.*

ТАВ V гэзэг тавьж ургуулахаар үлдээсэн дүгрэг ус; *тав тавих.*

ТАВ VI: тав хийх таг яг хийх чимээ; *хаалгыг тав хийтэл хаав.*

ТАВ VII: яв тав яг хийсэн, яг таг, яггүй, овоо, зэгсэн; *яв тав хийсэн хүн.*

ТАВААД 1. хүн тутам тав, тусбүр тав; 2. тав орчим.

ТАВААР 1. өртөг бүхий бөгөөд нийтэд арилжих, худалдах, худалдан авах замаар хувиарлагддаг хөдөлмөрийн бүтээгдэхүүн; *таваарын үйлдвэрлэл;* 2. ерөөс худалдахад зориулсан юм; **бараа таваар, эд таваар** х о р ш..

ТАВАГ I 1. пял, өргөн хавтгай ёроолтой, дэрэвгэрдүү амсартай сав; *шөлний таваг;* **таваг тавих** (идээ тавих); 2. жигнэх хэмжих хэрэгслийн дээр нь юм тавих хавтгай тогоо.

ТАВАГ II 1. тавхай; 2. тэмээний тавхай өвчин.

ТАВАГЛАХ I тавагт агуулах; *аянчин боорцог таваглаж байв.*

ТАВАГЛАХ II 1. малыг хөлөөс нь бэхлэн уях; *шөнө буураа таваглаж орхив;* 2. тавхайтсан тэмээний тавхайг шир зэргээр уллах; 3. ш и л ж с э н үйл ажилд суурьтай байх.

ТАВАГЛУУЛАХ таваглахын үйлдүүлэх хэв.

ТАВАГТАХ тэмээнд таваг өвчин тусах.

ТАВАЛЖИН таван өнцөг бүхий.

ТАВАНТАА таван удаа.

ТАВАРГАХ 1. таврахад хүрүүлэх; 2. хурдлан явах; *тэмээгээр таваргах; тарвага тавargаж явна;* 3. хол хол шидмэглэн оёх; *тавargаж оёх.*

ТАВГҮЙ 1. тохигүй, тухгүй; *яарч явсан учир тавгүй ороод гарав; тавгүй цагаар ирэв;* 2. муу, өвчтэй; **лагшин тавгүй** (бие муу, өвчтэй).

ТАВГҮЙДЭХ хэтэрхий тав тухгүй болох, тохигүйдэх.

ТАВГҮЙРХЭХ аягүй зан байдал гаргах.

ТАВГҮЙРЭХ тавгүй байдалтай болох.

ТАВГҮЙЦЭХ тавгүйрхэх, аягүйцэх.

ТАВДАН хөвхөн нимгэн хайрцаг авдар.

ТАВДАХЬ тавд тохиолдсон нь; *тавдахь удаагаа одонгоор шагнагдав.*

ТАВДУГААР тавдахь, тавд тохиолдсон нь; *тавдугаар сар.*

ТАВИАД 1. тавь орчим; *тавиад хонь; тавиад настай хүн;* 2. тус бүр тавь.

ТАВИГ тахих тайхад өргөх зүйл; **тахил тавиг** х о р ш.

ТАВИГДАХ тавихын үйлдэгдэх хэв; *намын өмнө тавигдсан зорилт.*

ТАВИГЛАХ тахих, тайх, өргөх.

ТАВИГЛУУЛАХ тавиглахын үйлдүүлэх хэв.

ТАВИЛ тавих үйлийн нэр; *шатрын тавил.*

ТАВИЛАН I хувь учрал; *би ч тавилан муутай юм шиг байна.*

ТАВИЛАН II мөрөн голын гарам гарц газар; *Сэлэнгийн тавилангаар гарч ирэв.*

ТАВИЛАНТАЙ хувь учрал бүхий; *би ийм тавилантай хүн байжээ.*

ТАВИЛГА I 1. тавьсан юм; *өргөл тавилга; барилга тавилга;* 2. онгод тахигласан хавтгай мод.

ТАВИЛГА II у р г а м а л мах шар болоод нягт нэг зүйл мод, үр улаан болоод хортой, идэж болохгүй.

ТАВИЛГАНА у р г а м а л тавилга модны нэг зүйл.

ТАВИН 1. илт, бэлэн зэлэн; *барин тавин хэлэх;* 2. баримц, зав чөлөөдөө; *энэ дээлийг би барин тавин хийсээр байгаад дуусгав;* **барин тавин** (үзсээр, харсаар, үзтэл, хартал; *тэр чинь барин тавин худал хэлдэг хүн байгаа юм*).

ТАВИНТАА тавин удаа.

ТАВИУ (Н) 1. уудам, уужим; **уудам тавиу** х о р ш.; 2. өнтэй, зуд гачиггүй; *өн тавиун;* 3. ш и л ж с э н сэтгэл огзом түргэн биш, тайван, амгалан, жаргалтай; *тавиун зантай хүн; тавиун аятай өдөр.*

ТАВИУДАХ хэтэрхийн тавиу болох.

ТАВИУЛ (АН) бүгд тавь.

ТАВИУЛАХ 1. тавихын үйлдүүлэх хэв; 2. тавигдах.

ТАВИУР 1. суурь, юм тавих хэрэгсэл; *лааны тавиур; зулын тавиур;* 2. тогооны таг, хавхаг.

ТАВИХ барих гэдэгтэй эсрэг утгатай үг; 1. барьсан, уясан, бэхэлсэн юмыг сул чөлөөтэй болгох, гаргах, тайлах, харвах; *нохой тавих; чөдрийнхөө морийг ижилд нь тавив; барьж байсан цулбууруа тавьж орхив; хундага тавилгүй архи ууж, хутга тавилгүй мах идэж...* (үлгэрээс); **гүү тавих** (а. барьж сааж байсан гүүг намар саахаа болих; б. уяатай байсан унагыг суллаж эхэд нь хөхүүлэх); **буу тавих** (буудах); **сум тавих** (сум харвах); 2. нэг юмыг нөгөөд нь тогтоох, бэхлэх, байлгах, оршуулах; *гуталд зан тавих; нөхөөс тавих;* **төөнө тавих** (халуун юмаар жигнэн түрэмдэх, хатгах); **жин тавих** (а. юмаар жигнэх; б. бусдыг битүүгээр егөх, хөнөөх; *үгээр жин тавих*); **хүн тавих** (хүн оршуулах; *хүн тавьдаг газар*); 3. хүнд зочлох юм өгөх; *идээ тавих; архи тавих; тавагтай идээ тавих;* 4. аливаа юмыг бий болгох, ургуулах, бүтээх, барих, байгуулах, босгох; *гээгээ тавих; сахал тавих; гэрэл тавих; утас тавих; радио тавих; шат тавих; гүүр тавих; төмөр зам тавих;* 5. бичих, зурах, будах; *нэрээ тавих; тоо тавих; тэг тавих;* **оо тавих** (оо түрхэх); **энгэсэг тавих** (эхнэр хүний нүүрэнд улаан будгаар мэнгэ хийх); 6. хэлэх, ярих, хашгирах, тараах; **өгүүлэл тавих** (ямар нэгэн юманд дургүйцэн олон юм ярих); **асуулт тавих** (асуулт асуух); **ерөөл тавих** (ерөөл хэлэх); **хараал тавих** (дахин давтан хараах); **илтгэл тавих** (илтгэх); **тайлан тавих** (тайлагнах); **дуу тавих** (а. бархирах: б. уйлах); **цуурхал тавих** (цуурхал яриа дэлгэрүүлэх); 7. аливаа юмыг үүсгэх, эхлэх; *үндэс тавих; суурь тавих; эхлэл тавих; үүсвэр тавих;* **гал тавих** (түймэр асаах); 8. наадах, тоглох; *хөзөр тавих; даалуу тавих; шатар тавих; даам тавих; буга тавих;* 9. хээлтүүлэгч мал болгох; *бух тавих; буур тавих; хуц тавих; ухна тавих; азрага тавих;* 10. тушаалд тохох; *дарга тавих; даамал тавих; өндөр тушаалд тавих;* 11. юмыг аливаа орчинд оруулах; *хагссан торхыг усанд тавив; наранд тавих; салхинд тавих;* 12. юмны амгалан тайван, урт, удаан болох; **өдөр тавих** (өдөр урт болох); **ган тавих** (гантай цагт бороо хур элбэг орох); **цаг тавих** (урин дулаан цаг ирэх); 13. анхаарах, мэрийж үзэх, шамдах; *анхаарал тавих; санаа тавих;* **амь тавих** (а. үлэмж мэрийх; б. амьс-

гал хураах); **чих тавих** (машид анхааран чагнах); **нүд тавих** (машид анхааран харах, ширтэх); 14. шуурах, салхилах; *шороо тавих; шуурга тавих; салхи тавих;* 15. жүжиг, кино мэтийг гаргаж үзүүлэх; *кино тавих; концерт тавих; жүжиг тавих;* 16. олгох, өгөх; *цалин тавих; нормын хувцас тавих; хүнсний ногоо тавих;* ☆ **найр тавих** (хөнгөмсөг эелдэг зан гаргаж зөвшөөрөх); **бөх тавих** (бөхийг барилдуулахаар гаргах); **саах тавих** саахалт хоёр айл хоорондоо саах нийлүүлэх); **ор тавих** (ор хийх, ор ихтэй болох); **морь тавих газар** (уралдааны хурдан морийг анх эхлэн давхиулах газар); **хугацаа тавих** (хугацаа тогтоох); **чөлөө тавих** (чөлөө олгох); **хориг тавих, хорио тавих** (а. хориг бий болгох; б. хориг үгүй болгох): **цээр тавих** (а. цээр бий болгох; б. цээр үгүй болгох); **тэмдэг тавих** (таних тэмдэг бий болгох); **хойш тавих** (хойшлуулах, хойргоших); **мөрий тавих** (мөрийцөх); **тагнуул тавих** (тагнагчийг явуулах); **ааруул тавих** (ааруцыг жижиглэж дэлгэц дээр дэлгэж хатаах); **сүрэг тавих** (малаа айлд тавьж бусдаар адуулуулах); **май тавих** (ихээр утаа гаргах); **мэдээ тавих** (мэдрэл алдах).

ТАВЛАГДАХ тавлахын үйлдэгдэх хэв.

ТАВЛАХ I юмыг бэхлэн хадахад, шаасан хадаас зэргийн үзүүрийг цохиж хавтгай болгох, тав гаргах; *хадаас тавлах.*

ТАВЛАХ II тайван, амгалан, тохитой, тухтай байх; *тохитой газар тавлан суух.*

ТАВЛАХ III бусдын гай зовлон, гэм буруу болоход хорт муу санаагаар баясах, бах ханах.

ТАВЛАХ IV хөзөр тоглоход таван ширхгээр гарах.

ТАВЛУУЛАХ 1. тавлахын үйлдүүлэх хэв; 2. тавлагдах.

ТАВНАН хуучирсан ноёдын хүргэн.

ТАВРАГА тарбага.

ТАВРАХ 1. тэмээний урд хөлөөрөө дэвсэлхийлэх, цохих; 2. тэмээний харайлган цогих маягтай явах; 3. хүний хурдлан харайлж явах.

ТАВРУУЛАХ таврахын үйлдүүлэх хэв, таврагах.

ТАВСАГ авдар мэт хөвхөн жижигхэн сав.

ТАВСАЙЛГАХ тавсайхын үйлдүүлэх хэв.

ТАВСАЙХ тавсгар болох.

ТАВСАЛЗАХ тавсгар юмны байн байн хөдлөх.

ТАВСАЛЗУУЛАХ тавсалзахын үйлдүүлэх хэв.

ТАВСАН I холыг харахад зориулан хийсэн өндөр тай.

ТАВСАН II дээд тал нь хавтгай; *тавсан толгойтой.*

ТАВСГАНАХ тавсгар юмны үргэлжлэн хөдлөх.

ТАВСГАР дээд этгээд нь хавтгайвтар юм; *тавсгар оройтой.*

ТАВТ таван тоо бүхий юм, таван ширхэг юм; *тавтын дэвсгэр.*

ТАВТАЙ I 1. тухтай, тохитой, аажим, чөлөөтэй; *тавтай сууж ярилцах;* 2. сэтгэлд тавиун, амар, тайван; *тавтай амрах; тавтай тарган өвөлжиж байна уу?* (мэндчилэх үг).

ТАВТАЙ II тав бүхий юм; *тавтай хадаас.*

ТАВТАЙЯА яг нийлэлцсэн, яг зохицсон, туйлын тохиромжтой, зохистой; *сэтгэлд тавтайяа нийлэлцэв.*

ТАВТАЛЬ ургамал зэрэг юмны бяцхан түрүү, бичил түрүү.

ТАВТИР томоо, суурь тогтвор; *тавтир муутай.*

ТАВТИР II дээлийн хоёр ташаа унжуу; *тавтир ихтэй.*

ТАВТИРГҮЙ тогтворгүй, сууригүй, номхон дөлгөөн биш, төлөв биш, онголзуур; *тавтиргүй мал; тавтиргүй хүн.*

ТАВУУЛ (АН) бүгд тав; *бид тавуул явж байна.*

ТАВХАЙ 1. хөлийн ул; 2. тэмээ, баавгай зэрэг амьтны хөл сарвуу; *тэмээний тавхай;* 3. тэмээний ул хагзрах нэгэн зүйл өвчин.

ТАВХАЙДАХ тавхай дээрээс нь шүүрэх, тагах.

ТАВХАЙЛГАХ тавхайхын үйлдүүлэх хэв, тавхгар болгох.

ТАВХАЙТАХ тэмээнд тавхай өвчин тохиолдох.

ТАВХАЙХ тавхгар болох.

ТАВХАР тавхгар.

ТАВХГАР 1. дээд тал нь хавтгай бөгөөд зузаан, тэвхгэр; *тавхгар толгойтой;* 2. зузаан хөрс давхралдан тогтсон нь.

ТАВЦАН 1. суух хэвтэхэд зориулсан хөмрөг, вандан; 2. тайз; **тайз тавцан** х о р ш.: 3. галт тэргэнд суух буухад зориулсан төмөр замын хажуу дахь талбай, өндөрлөг; *төмөр замын буудлын тавцан.*

ТАВШИХ хүний ар мөрөн дээр гарын алгаар зөөлөн цохих.

ТАВЬ (ТАВИН) таван арвын нийлбэр; *нэг мянга есөн зуун тавин долоон он; тавин мөнгөөр авсан; тавин нас хүрэв.* ;

ТАВЬДАХЬ тавьдугаарт тохиолдсон, тавьдугаар; *тавьдахь дэвтэр.*

ТАВЬДУГААР тавь дахь, тавьд тохиолдсон нь; *тавьдугаар пайз авсан морь.*

ТАВЬТ 1. тавин цэргээс бүрэлдсэн анги; *тавьт зуутаар жагсах;* 2. тавин тоо бүхий юм; *тавьтын дэвсгэр.*

ТАВЬЦ 1. тавих үйлийн явц; 2. тавьсан юм; тавьц нь бага байна.

ТАГ I уулын хавтгайвтар орой; *уулын таг;* **тагийн бүс** (өндөр ууланд ургах ургамлын бүс).

ТАГ II тогоо, данх мэт савны хавхаг; *тогооны таг; данхны таг.*

ТАГ III 1. огт чимээгүй; *таг болох; таг чимээгүй байх;* 2. огт, бүр; *таг зогсох; таг дүлий; таг сохор.*

ТАГ IV хатуу юм цохиход гарах чимээ; *мод цавчихад таг таг хийн сонсдож...*

ТАГ V арван оронтой тоо, арван миллиард.

ТАГАЛЦАГ малын нарийн шилбэний дорхи хэсэг; *хонины тагалцаг.*

ТАГДАЙЛГАХ тагдайхын үйлдүүлэх хэв, тагдгар болгох.

ТАГДАЙХ тагдгар болох; *дээл нь богинодон тагдайжээ.*

ТАГДАЛЗАХ тагдгар юмны байн байн хөдлөх.

ТАГДГАНАХ тагдгар юмны үргэлжлэн хөдлөх.

ТАГДГАНУУЛАХ тагдганахын үйлдүүлэх хэв.

ТАГДГАР тагжгар, тогжгор, охор, оготор; *тагдгар дээл; тагдгар өвгөн.*

ТАГЖГАНАХ тагжгар юмны үргэлжлэн хөдлөх. •

ТАГЖГАНУУЛАХ тагжганахын үйлдүүлэх хэв. •

ТАГЖГАР хэвийн хэмжээнээс оготор, богинохон, охор; *тагжгар нуруутай.*

ТАГЖИЙЛГАХ тагжийхын үйлдүүлэх хэв, тагжгар болгох.

ТАГЖИЙХ тагжгар болох.

ТАГЖИЛЗАХ тагжгар юмны байн байн хөдлөх.

ТАГЖИЛЗУУЛАХ тагжилзахын үйлдүүлэх хэв.

ТАГЖИРХАЙ тагжранхай.

ТАГЖИХ бөглөх, битүүлэх; *нүх тагжих.*

ТАГЖРАНХАЙ нүх сүв нь битүүрсэн, бөглөрсөн, онгорхой биш, тагжирхай; *тагжранхай хамар; тагжранхай нүх.*

ТАГЖРАХ тагжирхай болох, битүүрэх, бөглөрөх; *хамар тагжрах.*

ТАГЖРУУЛАХ тагжрахын үйлдүүлэх хэв.

ТАГЛИ хадаас зэрэгт тав гаргах нүхтэй төмөр багаж; *дархны тагли.*

ТАГЛАА 1. хавхаг, таг; **бөглөө таглаа** х о р ш.; *хувингийн таглаа;* 2. ш и л ж с э н үг хэлүүлэхгүй болгох хариу; *мэдэхгүй гэдэг, мянган үгний таглаа* з ү й р.

ТАГЛАРАХ битүүрэх, бөглөрөх, тагжрах; *тагларах бөглөрөх; нүх нь тагларчээ.*

ТАГЛАРУУЛАХ тагларахын үйлдүүлэх хэв.

ТАГЛАХ 1. хавхаглах, бөглөх; *зуух таглах;* 2. битүүлэх, бөглөх, хаах; *нүхийг шороогоор таглах;* 3. халхлах, далдлах; *нар таглаж зогсох.*

ТАГЛУУЛАХ таглахын үйлдүүлэх хэв.

ТАГНАЙ 1. амны доторхи дээд хонхор тал; 2. үедүүлж иржгэр гаргаж үйлдсэн хээ; *тагнай гаргах; тагнайтай даавуу;* 3. мод мэтийг залгахад гаргах догол, хэрчлээс; *үрганы тагнай; тагнай гаргаж залгах;* 4. адууны тагнай зузаарах нэг зүйл өвчин.

ТАГНАЙЛАХ тагнай гаргах.

ТАГНАЙРАХ 1. адууны тагнай зузаараад юм идэж чадахгүй болох; 2. тагнай мэт иржгэр ар бий болох.

ТАГНАЙТАХ тагнай өвчин тохиолдох.

ТАГНАЙШИХ: тагнайшсан гийгүүлэгч хэл, хатуу тагнайд ойртож зөөлрөх зэргээр дуудагдах гийгүүлэгч.

ТАГНАЙШУУЛАХ тагнайшихын үйлдүүлэх хэв.

ТАГНАХ ажиглах, турших, хянах, сэргийлэх; тагнах турших х о р ш.; *цэргийн хүчин чадал тагнах.*

ТАГНУУЛ 1. тусгай зорилгоор ямар нэгэн юмыг нууц аргаар мэдэх, мэдээлэх явдал; 2. цэргийн ба улсын нууцыг олж мэдэн өөр улсад уламжлан мэдүүлэх гэмт явдал; *тагнуул хийх; тагнуул тавих; тагнуул явуулах;* 3. тагнуулч; *нэг тагнуул явж байгаад баригдаж гэнэ.*

ТАГНУУЛАХ тагнахын үйлдүүлэх хэв, тагнуул хийлгэх, тагнуул болгох.

ТАГНУУЛЧ тагнуул хийдэг хүн.

ТАГНУУР 1. тариалангийн газар дээгүүр чирч шороо хэмхчих багаж, хөндлөн гулд солбицож үйлдсэн модонд төмөр шүдүүд хадсан байна; 2. тариалангийн шороог түвшитгэх багаж, модоор сүлжиж хийнэ.

ТАГТ давхарлаг гэр, давхар байшин; асар тагт, тай тагт х о р ш.; *тагт дээр гарч алсыг ширтэв.*

ТАГТАА а м ь т а н өнгө хөх цэнхэр буюу цайвар, том хөөтэй шувуу *тагтаа махчин шувуу биш; тагтааны өндөг;* энх тайвны тагтаа (энх тайвны билэг тэмдэг).

ТАГТАХ I доош урсан унжиж хөлдөх.

ТАГТАХ II дагтарших, давтах, зууралдах, өтгөрөх.

ТАГШ I хавтгайвтар хэлбэртэй, бяцхан модон аялга; *модон тагш.*

ТАГШ II у р г а м а л хөх цэцэгтэй, олон нарийхан навчтай, эхүүн үнэртэй, олон наст ургамал, хайрга, өнгэр газраар ургана .

ТАГШАА хээр бууж цайлах нь; *тагшаа хийх; тагшаа барих.*

ТАГШИХ I өвчний улмаас цээж дотор хөндүүр болох; *цээж тагших.*

ТАГШИХ II бүргэдийн дуугарах.

ТАГШУУЛАХ тагшихын үйлдүүлэх хэв.

ТАЖ нэгэн зүйлийн торгомсог бараа; *таж магнаг.*

ТАЖГАР тачир, намхан, нимгэн; *өвс ургамал тажгар газар; тажгар үстэй арьс.*

ТАЖИГНАХ хатуу юмны харших, хавирах, няцрах зэрэгт гарах чимээ; *морины хөл тажигнан дуугарав; ааруул тажигнатал идэж байв.*

ТАЖИЙХ тажгар болох.

ТАЙ I өртөөний буудаллах газар; *тайны гэр, өртөөний тай.*

ТАЙ II 1. байшингийн дээд талд барьсан асар, хотон; тай тагт х о р ш.; 2. сэргийлэх, манах буюу эсвэл техник хэрэгцээгээр өндөрт байгуулсан бяцхан цамхаг буюу ерөөс тийм газар; *тай дээр зогсож байгаа манаа.*

ТАЙВАН тавиу, амгалан, энх; амгалан тайван х о р ш.; *олон нийтийн амгалан тайван байдал; тайван суух; сэтгэл тайван байх; тайван цаг;* тавтай тайван байцгаана уу? (мэндчилэх үг); тайван хүн (амгалан хүн); энх тайван (эв найрамдалтай, амгалан тавиу, дайн дажингүй байдал; *дэлхий дахины олон түмэн хөдөлмөрчид энх тайвны төлөө, эзэрхэг түрэмгий хөрөнгөтөн, шинэ дайн өдөөгчдийн эсрэг тэмцэж байна).*

ТАЙВАНГҮЙ тайван байдалтай биш.

ТАЙВУУ I уужим тайван байдалтай; *тайвуу хүн.*

ТАЙВУУ II барилгын нуруу, хавирга нурууг тоссон бүдүүн мод.

ТАЙВУУ III х у у ч и р с а н урьдын цагт олгож байсан түшмэлийн цол.

ТАЙВШИРГАХ тайван шинж байдалтай болгох, тайвшраах.

ТАЙВШРААХ тайвшрахад хүрүүлэх.

ТАЙВШРАХ тавиу болох, тайван болох; *сэтгэл тайвшрах; дотор тайвшрах; цаг тайвшрав.*

ТАЙВШРУУЛАХ тайвшрахын үйлдүүлэх хэв; *сэтгэл тайвшруулах.*

ТАЙГА I хөвч, ой бүрхсэн өндөр аглаг уул нуруу; *тайга газар алхлуулж, хөндий газар хатируулж, хөвч газар сажлуулж...* (үлгэрээс); тайга уул, ой тайга, хөвч тайга х о р ш.; *тайгын ургамал; тайгын нүүдэлчид.*

ТАЙГА II урт хөлтэй, тачирхан үстэй маш хурдан гөрөөч нохой.

ТАЙГАН х у у ч и р с а н урьдын цагт агтлуулж, хааны өргөөнд зарагдаж явах хүн.

ТАЙД хашгирах аялга.

ТАЙЖ х у у ч и р с а н хаадын үгсаатан; *урьд тайж нар хамжлага албат нараар ажлаа хийлгэдэг байжээ;* хохь тайж (хамжлагагүй тайж); тайжийн жинс у р г а м а л (өргөслөг

навчтай, хөхөвтөр бөгөөд бөөрөнхий толгойтой ургамал, ихэнхдээ ойт хээрийн бүсэд ургана).

ТАЙЗ I хуучирсан урьдын цагт хаан ширээнд суух хөвгүүн; **тайз одон** зурхай (Алтан гадас одыг тойрох тэргүүн од).

ТАЙЗ II ший жүжиг тоглоход зориулсан тавцан; *тайзны заслал; эргэдэг тайз.*

ТАЙЛАГ тэмээний гурван наснаас таван нас хүртлэхийг нь; *дөрвөн шүдтэй тайлаг; тайлаг тайлаг тэмээнээс, таван атга шорооноос* (оньсго худалдахад хэлэх үг): **битүү шүдтэй тайлаг** (шүд нь гараагүй тайлаг).

ТАЙЛАГДАХ 1. тайлахын үйлдэгдэх хэв; *зангилаа тайлагдах; хаалга тайлагдах;* 2. чөлөөлөгдөх, хэлтрэгдэх; *хичээлээс тайлагдах; албанаас тайлагдах;* 3. мэддэг болох; *шинэ үсэгт тайлагдах.*

ТАЙЛАЛ тайлах үйлийн нэр; оньсгын тайлал; *үгийн сүлжээний тайлал.*

ТАЙЛАН 1. орлого зарлагыг харьцуулан тодорхойлсон данс; **данс тайлан, бүртгэл тайлан** хор ш.; *тайлан гаргах; зарцуулсан мөнгөний тайланг гаргах;* **тайлан данс** (зарсан зүйлийг тодорхойлсон данс); 2. ажил хэргийн тухай хийх мэдэгдэл, илтгэл; *сонгогчдод тайлангаа гаргах;* **тайлан-сонгуулийн хурал** (албан тушаалд сонгогдогсод зохих хугацаанд хийсэн ажлынхаа талаар сонгогчдын өмнө илтгэж, шинээр сонгууль хийх хурал).

ТАЙЛАХ 1. зангилсан уясан зүйлийг алдруулах; *зангилаа тайлах;* 2. хувцсыг биеэс огцруулах, салгах; *дээл тайлах; гутал тайлах; бүс тайлах;* 3. цоож, оньс мэтийг сул болгох; *хаалганы оньсыг тайлав;* 4. үг, бичиг зохиолын утга санааг гүнээ дэлгэрүүлэн заах; *үг тайлах; тайлж хэлж өгөх; оньсго тайлах;* 5. мэддэг болох; *бичиг үсэгт тайлах; бид эхлээд хөгжмийн анхны мэдэгдэхүүн зааж тайлдаг;* 6. аливаа гүнээ санаашран бодсон юмыг шийдвэрлэх, тайтгаруулах; *гомдол тайлах; уйтгар тайлах;* ☆ **үй гашуу тайлах, гашуудал тайлах** бэлбэсрэх хугацааг дуусгаж ёс гүйцэтгэх); 7. оногдол албанаас хэлтрүүлэх, чөлөөлөх; *өртөөний албанаас тайлах;* **нүд тайлах** (их юм үзэх; *юм үзэж нүд тайлах*); **хор тайлах** (хор устгах; *хор тайлах эм; архины хор тайлах*).

ТАЙЛБАР утгыг тайлбарласан бичиг, нэмэн дэлгэрүүлж хэлсэн зүйл; **тайлбар болгох** (учрыг дэлгэрүүлэн хэлэх); ☆ **тайлбар толь** (үгийн утгыг дэлгэрүүлэн тайлсан толь бичиг).

ТАЙЛБАРЛАГЧ тайлбарлах үүрэгтэй хүн; *музейн тайлбарлагч.*

ТАЙЛБАРЛАЛ тайлбарлах үйлийн нэр; *тайлбарлал хийх; тайлбарлал гаргах.*

ТАЙЛБАРЛАХ юмны утга учрыг дэлгэрүүлэн таниулж өгөх; *би учры нь мэдэхгүй байна, та над тайлбарлаж өгнө үү? музейд удаан жил ажилласан тул тайлбарлахдаа маш чадамгай болжээ.*

ТАЙЛБАРЛАШГҮЙ тайлбарлах аргагүй.

ТАЙЛБАРЛУУЛАХ тайлбарлахын үйлдүүлэх хэв.

ТАЙЛБАРЛУУШТАЙ тайлбарлавал зохистой.

ТАЙЛБАРЧ тайлбар хийдэг хүн, тоймч.

ТАЙЛГА тахилга; *тайлга тахилга* хор ш.

ТАЙЛДАХ тайлагдах.

ТАЙЛИАН нэг тал нь гилгэр, нөгөө тал нь арзгар нимгэн цаас; *тайлиан цаас.*

ТАЙЛЛАГА юмны нам, төрөл, аймгийг ялган салгаж тэмдэглэсэн бичиг тайлбар.

ТАЙЛАГДАХ тайлахын үйлдэгдэх хэв.

ТАЙЛУУЛАХ 1. тайлахын үйлдүүлэх хэв; 2. тайлагдах.

ТАЙР бугын эр нь.

ТАЙРАГДАХ тайрахын үйлдэгдэх хэв.

ТАЙРАЛЗАХ тайргар юмны байн байн хөдлөх.

ТАЙРАНХАЙ тайрагдсан юм.

ТАЙРАХ урт өндрөөс хасах, богино нам болгох; *үзүүрий нь тайрах; уртаас нь тайрах; хөрөөгөөр тайрах; гэзгээ тайрах.*

ТАЙРГАНАХ тайргар юмны үргэлжлэн хөдлөх.

ТАЙРГАР янхигар том, биерхүү.

ТАЙРДАС тайрагдсан юм; *модны тайрдас.*

ТАЙРИЙЛГАХ тайрийхын үйлдүүлэх хэв.

ТАЙРИЙХ тайргар болох.

ТАЙРМАЛ тайрсан нь; *тайрмал гээг.*

ТАЙРУУЛАХ 1. тайрахын үйлдүүлэх хэв; 2. тайргадах.

ТАЙТАЛЗАХ майжилзах, хазалзах.

ТАЙТАЛЗУУЛАХ тайталзахын үйлдүүлэх хэв.

ТАЙТГАНАХ майжигнах, хазганах.

ТАЙТГАР тойг дотогш муруй, майга; *тайтгар хөлтэй хүүхэд.*

ТАЙТГАРАХ 1. сэтгэл засагдаж, дотор уужрах, сэтгэлийн гунил зовлон тайлагдах; *битгий зов, тайтгарч үз;* 2. хилэгнэсэн нь намжих, уур дарагдах; *манай энэ охин үйлж л байж тайтгардаг юм.*

ТАЙТГАРУУЛАХ тайтгарахын үйлдүүлэх хэв.

ТАЙТГАРШГҮЙ тайтгарах, тавирах аргагүй; *тайтгаршгүй зовлонд учирчээ.*

ТАЙХ тахиглах, тахих; *тайх тахих* х о р ш.; *уул тайх; онгод тайх.*

ТАЙШ х у у ч и р с а н түшмэлд олгож байсан нэгэн зүйл цол.

ТАКСИ хөлсний тэрэг; *такси дуудах; таксины буудал.*

ТАКТИК 1. дайны арга ухаан; 2. нийгэмулс төрийн тэмцэл явуулах арга ажиллагааны цогц.

ТАКТИКЧ тактикт мэрэгжсэн хүн.

ТАЛ I уул даваагүй уудам цэлгэр газар; *тал газар; уудам тал; нүд алдам тал харагдав; талын өргөс түүхээр, тавгийн тахаа зузаал* з ү й р.

ТАЛ II 1. этгээд, зүг; *гадна тал; дотор тал; өвөр тал; өргөн тал; наршин тал; хажуу тал; дээд тал; доод тал; урд тал; хойт тал; тал талд нь гарч үзэх; баруун тал; зүүн тал;* **ар тал** (а. ар этгээд; б. дайтаж байгаа шугамын ар этгээд, дайны фронтын ар этгээд, нутаг орон);2. хагас; *тал талх; тал бие; тал бөмбөрцөг; тал дүгүй хэлбэртэй; тал сар;* **тал хувь** (хоёр хуваасны нэг); 3. нөгөөгийн эсрэг байгаа хэсэг; *манай талаас гарах бөх; нэг тал болох;* 4. хавтаг хавтгай; *найман талтай;* 5. **нэгэн тал нь бодитой, гүйцэд биш;** *тал торго; тал цэмбэ;* 6. ш и л ж с э н чанар, байдал; *сайн тал; муу тал; тал бүхнээс нь ажиглах.*

ТАЛ III дотно, найз, дотно танил; **танил тал** х о р ш.; **тал засах** (танил, дотно байхыг хичээх); **тал харах, тал тохой татах** (танилаа дотночлон үзэх, өмгөөлөх).

ТАЛ IV: **тал тул** халт мөлт ,хазгай муруй; *монголоор тал тул ярих юм.*

ТАЛААР I дэмий, хэрэггүй, тусгүй; *талаар хэрэг; талаар битгий тэг! олон дахин очсон минь талаар болсонгүй.*

ТАЛААР II ямар нэгэн үйл хэргийн тухайд; *олон улсын харилцааны талаар; эдийн ясчанарыг сайжруулах талаар; санхүүгийн асуудлын талаар; хичээл сурлагын талаар; тооны талаар голлон анхаарах бишүү, чанарын талаар юуны өмнө бодох хэрэгтэй.*

ТАЛАГДАХ талахын үйлдэгдэх хэв; *дээрэмчинд талагдах.*

ТАЛАРХАГ талархахдаа дуртай; *тэндэхийн нөхдүүд их л талархаг юүлзав.*

ТАЛАРХАГДАХ талархахын үйлдэгдэх хэв.

ТАЛАРХАЛ талархсан сэтгэл; *талархал хүргэх; гүн талархлаа илэрхийлэх; талархал хүлээх.*

ТАЛАРХАХ талархал илэрхийлэх, ачийг санаж баярлах; *таны хийсэн тусад машид талархав.*

ТАЛАРХУУ талархаг зантай.

ТАЛАРХУУЛАХ 1. талархахын үйлдүүлэх хэв; 2. талархагдах.

ТАЛАХ бусдын эд юмыг цөлбөн авах, дээрэмдэх; **алах талах** х о р ш.; *дээрэмчид, энгийн номхон ард иргэдийг алж талж зовлон гамшиг учруулж байв;* **харайх барайхы нь талах** (хамаг юмы нь хураах).

ТАЛБАГ гадар татаж хийсэн орны дэвсгэр.

ТАЛБАЙ талбар; *биеийн тамирын талбай.*

ТАЛБАР 1. талбай, сургууль боловсруулах уудам газар; *буудлагын талбар; сурын талбар; онгоц буух талбар;* 2. хот суурин дахь барилга бариагүй, тэгш уудам газар; тал тал *тийшээ гудамж гарна; Улаанбаатар хот дахь Сүхбаатарын талбар;* 3. *тариалангийн талбай; тариалангийн талбар.*

ТАЛБИРАХ 1. уужрах, тайвшрах, уудам тавиу болох; *сэтгэл талбирах;* 2. өнтэй сайхан болох; *цаг талбирах.*

ТАЛБИРУУЛАХ талбирахын үйлдүүлэх хэв, талбиу болгох.

ТАЛБИУ талвиу; *дээлийнхээ сугыг жаахан талбиу шиг хийгээрэй.*

ТАЛИЙГААЧ талийгч; *талийгаач эгч минь их ажилсаг хүн байсан юм.*

ТАЛИЙГЧ нас барагч, өнгөрөгч, талийгаач; *талийгчийг байхад...*

ТАЛИЙЛГАХ талийхын үйлдүүлэх хэв.

ТАЛИЙХ 1. арилж өгөх, бараа сураггүй хол явчих; *тэд өдийд талийж өгсөн байх ёстой;* 2. үхэх.

ТАЛЛАГДАХ таллахын үйлдэгдэх хэв.

ТАЛЛАХ 1. юмыг дундуур нь хуваах, хагаслах; *дундуур нь таллах;* 2. тал талаас нь авах; *ууц таллах* (хонины чанасан ууцыг хоёр этгээдээс нимгэн нимгэнээр зүсэж авах); 3. талцах, талсах; *таллаж тоглох; таллаж тэмцэх.*

ТАЛЛУУЛАХ 1. таллахын үйлдүүлэх хэв; 2. таллагдах.

ТАЛМИА нүдний харц зөөлөн тогтниун байдал.

ТАЛМИАРАХ талмиатах, талмиа болох.

ТАЛМИАТАХ нүдний харц зөөлөн тогтниун болох.

ТАЛОН 1. бүхэл баримт бичгийн хэсэг, бас хэсэг хэсэг тасалсан баримт; *хоолны талон; талон бичүүлэх; талон таслуулах;* 2. юм авсны баримт, шалгавар болох хуудас.

ТАЛС олон тал.

ТАЛСАГ I олон талтай чулуулаг; *талсаг чулуу.*

ТАЛСАГ II талархамтгай, талархаг; *сүрхий талсаг хүн.*

ТАЛСТ талс бүхий хатуу бодис.

ТАЛСТАХ талстай болж тогтох; *давс талстах.*

ТАЛСТУУЛАХ талстахын үйлдүүлэх хэв, талстай болгох.

ТАЛТ I тал бүхий; *олон талт.*

ТАЛТ II: **талт мөлт** халт мөлт; *талт мөлт сонсох; талт мөлт хийх.*

ТАЛТ III олонтой, танил тал бүхий.

ТАЛТАЙ I тал бүхий.

ТАЛТАЙ II танил бүхий; *талтай хүн талын чинээн, танилгүй хүн алгын чинээн* з ү й р.

ТАЛТАЛХИЙЛЭХ талталхийх.

ТАЛТАЛХИЙХ хэлээ дэвсэн, хэлээ хазаж үг ярих.

ТАЛТЬ талти.

ТАЛУУЛАХ талахын үйлдүүлэх хэв.

ТАЛХ I гурилаар жигнэж хийх идээ; **талх тариа** х о р ш.; *хар талх; цагаан талх; талх зүсэх; талхны газар; талхны дэлгүүр; талхны хөрөнгө;* **талх барих** (талх хийх).

ТАЛХ (АН) II нунтаг; *талхан эм;* **талх болгох** (нунтаг болгох).

ТАЛХДАХ талхлах, нунтаглах.

ТАЛХИ I арьс элдэх зэвсэг: **талхины нугас** (талхины хөндлөвч); **талхины хэл** (талхины даруулга); **талхины даруулга** (талхины даруул мод).

ТАЛХИ II 1. х у у ч и р с а н нэгэн зүйл эрүү шүүлт; 2. ш и л ж с э н зовоох үйлийн нэр, талхидал, талхигдал.

ТАЛХИГДАЛ дарлал зовлон; *хөрөнгөтний талхигдал.*

ТАЛХИГДАХ талхихын үйлдэгдэх хэв, дарлагдах.

ТАЛХИДАГДАХ талхидахын үйлдэгдэх хэв.

ТАЛХИДАЛ зовлон зүдгүүр.

ТАЛХИДАХ I 1. талхих; 2. дэмий үгээр хуурах.

ТАЛХИДАХ II х у у ч и р с а н талхи шүүлт тулгах.

ТАЛХИДУУЛАХ талхидахын үйлдүүлэх хэв.

ТАЛХИУЛАХ 1. талхихын үйлдүүлэх хэв; 2. талхигдах.

ТАЛХИХ I арьсыг талхиар элдэх; *арьс талхих.*

ТАЛХИХ II 1. үргэлж эдэлж зовоох; *зуны турш ганц морио талхилаа шүү дээ, чи;* 2. ш и л ж с э н дарлах, зарцалж зовоох; *ядуу ардыг ноёд баяд талхин зовоож байв.*

ТАЛХЛАГДАХ талхлахын үйлдэгдэх хэв.

ТАЛХЛАХ I нунтаглах, нунтаг болгох; *эм талхлах.*

ТАЛХЛАХ II хөл үймээнд нэрвэгдэн сүйрэх.

ТАЛХЛУУЛАХ 1. талхлахын үйлдүүлэх хэв; 2. талхлагдах.

ТАЛЦААХ тал тал болгох, тал тал болоход хүргүүлэх.

ТАЛЦАХ тал тал болох; *талцаж барилдах; галцаж тэмцэлдэх.*

ТАЛЦУУЛАХ талцахын үйлдүүлэх хэв.

ТАМ I. 1. шашны ёсны гурван муу заяа гэгчийн нэг, зовлон эдлүүлж зовоох газар; *халуун там; хүйтэн там; арван найман там; тамын зовлон эдлэх; тамын амьтан тамдаа жаргалтай* з ү й р; 2. ш и л ж с э н зовлон гаслантай орон; *тамаа эдлэх;* **тамаа цайж явах** (а. зовох, зүдрэх; б. тамтаггүй буруу явсны үр боловсролыг эдлэх); 3. **маш** гүнзгий нүх; *уулыг тал болтол, талыг там болтол ноцолдов гэнэ* (үлгэрээс).

ТАМ II тооны нэр, арван равжим.

ТАМАА а м ь т а н шаахайн ул мэт хэлбэртэй нэгэн зүйл загас, далайд оршино.

ТАМАХ I томох; *утас тамах; дээс тамах.*

ТАМАХ II 1. авын орхигдсон газрыг түрэглэн хурааж авах; 2. зам муруйх.

ТАМГА 1. засаг төрийн **захирах байгууллагын** албан бичиг хэрэгт дардаг засаглах эрхийн баталгаа болох оноосон нэртэй сүлд бүхий захирлага тэмдэг; мөн түүнийг цаас зэрэг дээр дарсан нь; *ямны тамга; төрийн тамга; тамга дарсан бичиг; 2.* х у у ч и р с а н хушуудын төрийн хэрэг шийтгэх газар; *хушууны тамгын газар; шавийн тамгын газар; тэдний тамганд тушаав; тамганд хэрэг мэдүүлэх; тамганд заалдах; тамганд захирагдсан ард;* 3. адуу мал, эд юманд тэмдэг болгон хайрах төмөр хэрэгсэл; *чандмань тамгатай хээр морь; ташаан дээр нь дарсан тамга нь таван номын үсэгтэй дээ хөө* (дуу); 4. **хөзрийн** нэг зүйл дүрс тэмдэг; *буйманғийн тамга; дөрвөлжингийн тамга; тамгаар гарав.*

ТАМГАЛАГДАХ тамгалахын үйлдэгдэх хэв.

ТАМГАЛАХ тамга дарах; *бичиг тамгалах; адуу тамгалах.*

ТАМГАЛУУЛАХ 1. тамгалахын үйлдүүлэх хэв; 2. тамгалагдах.

ТАМГАТ тамга бий.

ТАМГАТАЙ тамга тэмдэг бүхий юм; *тамгатай газар; тамгатай цаас; тамгатай мал.*

ТАМИР 1. чадал тэнхээ; **чадал тамир** х о р ш.; *тамир орох;* **тамир доройтох** (тамир тэнхээ буурах); **тамираа үзэх** (тамир тэнхээгээ сорих); **тамир барах** (зүдэх, зүдрэх); **биеийн тамир** (бие махбодыг хөгжүүлэх, бэхжүүлэхээр үйлдэх сургууль, дасгал; *биеийн тамир хийх);* 2. ш и л ж с э н санаа; **дотуур тамир** (санаа муу); **гадуур тамир** (хуурамч зан).

ТАМИРГҮЙ 1. чадал тэнхээ муутай; 2. дотуур муу санаа байхгүй, цагаалхай, **цайлган.**

ТАМИРГҮЙДҮҮЛЭХ тамиргүйдэхийн үйлдүүлэх хэв.

ТАМИРГҮЙДЭХ хэтэрхий тамиргүй болох, чадалгүйдэх, тэнхээгүйдэх.

ТАМИРДАХ 1. тамир доройтох, тэнхээ муудах; *нас өтөлж тамирдах;* 2. тамир хүрэхгүй болох, тэнхээ гүйцэхгүй болох, эцэх, цуцах; *бие ядуу учир өндөр шат өөд гарахдаа тамирдаж байв.*

ТАМИРДУУЛАХ тамирдахын үйлдүүлэх хэв.

ТАМИРЖИХ тамир суух, тэнхээ орох; *сайн хоол идэж хурдан тамиржив.*

ТАМИРЖУУЛАХ тамиржихын үйлдүүлэх хэв, тамиртай болгох.

ТАМИРТ тамиртай; *биеийн тамирт дуртай.*

ТАМИРТАЙ тамир бүхий, чадал тэнхээ сайтай; **дотуур тамиртай** (санаа муутай).

ТАМИРЧ биеийн тамирт мэрэгжсэн **хүн;** *биеийн тамирч.*

ТАМЛАГДАХ тамлахын үйлдэгдэх хэв.

ТАМЛАГЧ тамалдаг этгээд, тарчилган зовоогч этгээд.

ТАМЛАХ I тарчилган зовоох; *тамалж алах; тамалж зовоох.*

ТАМЛАХ II бөө нарын онгондоо **залбирах.**

ТАМЛУУЛАХ 1. тамлахын үйлдүүлэх хэв; 2. тамлагдах.

ТАМПРАМ у р г а м а л цайвар шар цэцэгтэй, эхүүн үнэртэй, хорт ургамал, эмнэлэгт *хэрэглэнэ.*

ТАМС 1. чийрсэн дэвсгэр мэт юмны мөшгөөр хөвөө; 2. **өөшний** хэлхээ оосор; 3. цалмын дээс.

ТАМСАГ тансаг.

ТАМСАГЛАХ гоёх, гангалах, хээнцэрлэх.

ТАМТАГ элэгдэж урагдан зэмдэг болсон юм, оронцог; *дээлийн тамтаг; гэрийн тамтаг.*

ТАМТАГГҮЙ 1. авч хэрэглэх аргагүй, зэмдэг болсон; *авахын тамтаггүй юм;* 2. дүрсгүй, зүггүй, төлөвгүй; **тамтаггүй явбал тамд унана** (зовлонд орно).

ТАМТАГЛАГДАХ тамтаглахын үйлдэгдэх хэв.

ТАМТАГЛАХ 1. тамтахын үйлдүүлэх хэв, тамтаг болгох; 2. зэмдэглэх, муу чанартай үйлдэх.

ТАМТАГЛУУЛАХ 1. тамтаглахын үйлдүүлэх хэв; 2. тамтаглагдах.

ТАМТАХ тамтаг болох.

ТАМТЛАХ 1. тамтаглах, өвдэж сүйтгэх; 2. зовоож гачигдуулах.

ТАМТРАХ 1. тамтаглах, тамтаг болох, элэгдэж урагдах; *дээл тамтрах;* 2. ш и л ж с э н хоосрох, доройтох; *хөрөнгө үрэгдэж тамтрах.*

ТАМТРИХ малын өвс ногоо-алгуур зулгаан идэх.

ТАМТУМ хальт мөлт, дутуу мөчид, хагас дутуу; *тамтум сонсох; тамтум хийх.*

ТАМТУМЛАХ тамтум болгох.

ТАМТЧИХ олныг тамтаглах.

ТАМТЧУУЛАХ тамтчихын үйлдүүлэх хэв.

ТАМХИ (Н) 1. у р г а м а л өнгө ногоон, навч, том нэг зүйл өвс; *тамхи тарих; тамхи хатаах;* 2. мөнхүү ургамлыг хатааж хэмхчин боловсруулаад, татах үнэрлэхэд бэлэн болгосныг; *ороодог тамхи; хатуу хайрцагтай тамхи; улаан тамхи; шар тамхи; дүнсэн тамхи; тамхины хүүдий; тамхины навч; тамхины хор;* **хар тамхи** (а. у р г а м а л намуу цэцгийн төрөл, урт бөгөөд том навчтай, шар буюу улаан цэцэгтэй ургамал: б. мөн ургамлыг гүйцэд боловсроогүй байхад огтолж шүүсий нь авч хатаасныг); **хамрын тамхи** (үнэрлэхэд зориулж хийсэн нанги тамхи); **тамхинд орох** (тамхины утааг сорох буюу хамрын тамхийг үнэрлэсээр түүнд тэсгэлгүй шунахай болох); **тамхинаас гарах** (тамхинд дуртай болсон **хүн түүнийг татахгүй болох**).

ТАМХИЛАХ тамхиа харилцан солилцож татах; *хөөргөө гарган тамхилав.*

ТАМХИЛУУЛАХ тамхилахын үйлдүүлэх хэв.

ТАМШАА 1. тоомсоргүй, их зантай юм шиг байдалтай; *тамшаа зан; тамшаа байдал;* 2. идэх уухдаа хомхой байдалтай биш, тансаг хангалуун; *тамшаа идэштэй хүн; идэхдээ тамшаа хүн.*

ТАМШААЛАХ тамшаа байдал гаргах.

ТАМШААЛГАХ тамшаахын үйлдүүлэх хэв.

ТАМШААЛУУЛАХ тамшаалахын үйлдүүлэх хэв.

ТАМШААХ I 1. юмны амтыг үзэхэд уруулаа байн байн хавсран салгах; *амталж тамшаах;* 2. дургүйцэх байдал гаргаж амаа ангасхийж шавхийлгэн дуугаргах; *дургүй янзтай тамшааж байна билээ.*

ТАМШААХ II нумын сайн мууг үзэхээр нумыг өчүүхэн татаж тавих; *нум тамшаах.*

ТАН I ургамлын зүйлийг нүдэж хийсэн, хандалж уудаг бүдүүн ширхэгтэй эм; **эм тан** х о р ш.

ТАН II: тан газар голын журамгүй элс чулуутай газар.

ТАН III: тан хийх (а. юмыг цохих, дэлдэх дуугаргахад гарах чимээ; *тан тан хийх; тан түн хийх;* б. хатуу нумыг тамшаалгахад гарах дуу.

ТАН IV хоёрдугаар биеийн төлөөний үг; *би тантай уулзах хэрэгтэй юм сан; танаас хүсэх нэг зүйл байна... танаар дамжуулан өгсөн захидал.*

ТАНА (Н) зарим дунгийн дотоод хатуу хөрс болох солонголох өнгөтэй эд, чимгийн зүйлд хэрэглэнэ *танан товч.*

ТАНАГ I 1. олигтой, бузгай байдал; *танагаа алдах; танаг тасрах;* 2. тэнхэл, тэнхээ, чадал; *танаг сайтай байна.*

ТАНАГ II: сураг танаг (мэдээ сураг); *сураг танаг байхгүй болжээ.*

ТАНАГГҮЙ 1. ихэд урагдаж эвдэрсэн; *авахын танаггүй болох;* 2. төлөв зэхий, адгийн муу; *танаггүй муу хүн;* 3. сураг мэдээгүй; *сураг танаггүй алга болсон байна.*

ТАНАГДАХ танахын үйлдэгдэх хэв.

ТАНАГТАЙ 1. асар муу биш, овоо, бузгай, арай дээр; *танагтай байгаа майхан;* 2. тэнхэлтэй, чадалтай, өтөлж ядраагүй; *танагтай байхад нь хүү нь иржээ.*

ТАНАЙ хоёрдугаар биеийн төлөөний үг; *танай байгаа сургууль; танай гэр; танай улс.*

ТАНАЙХЬ танай өөрийнх; *танайх тэр нутагтаа суурин байх уу? танайхь, хэнийтэй айл бэ? танайхь хэдүүл бэ?*

ТАНАМАЛ танасан юм, хяргамал, тайрмал; **хасмал танамал** х о р ш..

ТАНАР: **үнэр танар** үнэр; *үнэр танар нь муухай юм.*

ТАНАХ дээл хувцас зэргийн юмнаас өөлөх, бага зэрэг тайрах, хяргах, хасах; *уртаас нь танах; эргэн тойрон танах.*

ТАНГАЛЗАХ цээж түрж бардамнан аашлах.

ТАНГАРАГ батыг үзүүлэн амалдсан үг, бичиг; *цэргийн тангараг;* **тангараг тавих** (амалдах); **тангараг алдах, тангараг няцах** (амалдсанаасаа буцах); **тангаргийн гэрээ** (амалдаж тогтсон гэрээ).

ТАНГАРАГЛАЛ тангараглах үйлийн нэр; *тангараглал хийх.*

ТАНГАРАГЛАХ амалдах, тангараг тавих; *эх орондоо үнэнч зүтгэнэ гэж тангараглав.*

ТАНГАРАГЛУУЛАХ тангараглахын үйлдүүлэх хэв.

ТАНГАРАХ морь малын хойт хоёр хөлөөр зэрэг өшиглөх; *азрага тангарах.*

ТАНГАРУУЛАХ тангарахын үйлдүүлэх хэв.

ТАНГАЧИХ байн байн тангарах.

ТАНГАЧУУЛАХ тангачихын үйлдүүлэх хэв.

ТАНГИС тэнгэс.

ТАНДАХ I онгоц, завийн гүйхэн усанд газардан ёроолд тулж явахгүй болох.

ТАНДАХ II юмны байдал төлөвийг ажиглан туршиж явах; **тагнах тандах** х о р ш..

ТАНДАХ III тагнуур чирч тариалангийн газар засах.

ТАНДУУ тарианы газрыг тандах хэрэгсэл.

ТАНДУУЛАХ тандахын үйлдүүлэх хэв.

ТАНЗУУР зуурсан гурилыг жижиг бөмбэлөг болгож тосонд чанаад элсэн чихэрт өнхрүүлсэн нэгэн зүйл боов.

ТАНИГДАХ танихын үйлдэгдэх хэв.

ТАНИГДАШГҮЙ танихын аргагүй; *манай хотын байдал танигдашгүй болтлоо өөрчлөгджээ.*

ТАНИЛ бие биеэ мэдэх бөгөөд ямар нэгэн ашиг сонирхлын талаар холбоо бүхий хүн; **танил тал** х о р ш.; *танил хүн; танил болох.*

ТАНИЛГҮЙ таних олон нөхөргүй буюу ганцагчин байдалтай хүн; *танилгүй хүн алгын чинээн.*

ТАНИЛТАЙ танил олонтой, танил ихтэй, олон нөхөдтэй; *танилтай бол талын чинээн.*

ТАНИЛЦАХ 1. харилцан бие биеэ мэдэлцэж авах, танил болох; *тэр хотод нэг өвгөнтэй танилцав;* 2. юмны учир байдлыг ойлгох, мэдэрч авах; *энэ бичгийн утгатай танилцаж амжаагүй байна; тэр тогтоолын төсөлтэй танилцав.*

ТАНИЛЦУУЛАХ танилцахын үйлдүүлэх хэв, танилцахад хүрүүлэх.

ТАНИМГАЙ танихдаа сайн, таньдаг танимхай.

ТАНИМГАЙРАХ танимгай болох.

ТАНИМГАЙРХАХ танимгай байдал гаргах.

ТАНИМХАЙ танимгай.

ТАНИР 1. анир; **анир танир** х о р ш.: 2. сураг, чимээ; **сураг танир** х о р ш..

ТАНИРЛАХ 1. үнэрлэх; **үнэрлэх танирлах** х о р ш.; 2. анир сураг сонсох; 3. х у у ч и р с а н бөөгийн шашны ёсны тахигласан юмны уурыг хувилгаан онгоддоо авах.

ТАНИУЛАХ 1. танихын үйлдүүлэх хэв; *ухуулан таниулах ажил;* 2. танигдах.

ТАНИУЛГА таниулах үйлийн нэр; **яриа таниулга, ухуулга таниулга** х о р ш.; *таниулга явуулах; таниулгын ажил; таниулгын хурал.*

ТАНИХ юмыг мэдэх, ялгах, олж харах; *би чамайг таньж байна; таних дуу гарлаа; үсэг таних; малаа таних; өвчин таних; таних нө-*

хөр тохиолдов; танихаасаа урьд талын хоёр гөрөвөс, танилцсан хойноо тагнайн хоёр судас з ү й р.

ТАНИХГҮЙ мэдэж ялгаж чадахгүй; *хүн танихгүй, газар мэдэхгүй; танихгүй бурхнаас таньдаг чөтгөр дээр* з ү й р.

ТАНИШГҮЙ танихын шинжгүй, таних аргагүй; *танишгүй өвөр болжээ.*

ТАНК хүчтэй зэвсэг бүхий бөгөөд гинжин дугуйтай хуягтай машин; *танкийн цуваа; хүнд танк; танкийн хороо.*

ТАНСАГ 1. баясалтай, сайхан, зохистой, амтлаг; **тансаг амт** (сайхан амт); **тансаг үг** (сайхан үг); **тансаг идээ** (хэтэрхий сайхан идээ); 2. хэтэрхий хайрлагдсан; *тансаг өссөн хүүхэд;* 3. идээнд ханалтай; *тансаг идэштэй*).

ТАНСАГЛАГДАХ тансаглахын үйлдэгдэх хэв.

ТАНСАГЛАХ I идээ ундаанд ховдоглохгүй ханалтай аашлах.

ТАНСАГЛАХ II хүүхэд зэргийг хэтэрхий хайрлаж эрхлүүлэх.

ТАНСАГЛУУЛАХ 1. тансаглахын үйлдүүлэх хэв; 2. тансаглагдах.

ТАНТАЙЛГАХ тантайхын үйлдүүлэх хэв.

ТАНТАЙХ тантгар болох.

ТАНТАН нус цэр хаях сав; *хогийн тантан.*

ТАНТАР: тантаг тунтар энд тэнд; *тантар тунтар алхаад гарч явав.*

ТАНТГАР юмны хэвийн жишээнээс тэнтгэр, луглагар, бүдүүн.

ТАНУУЛАХ 1. танахын үйлдүүлэх хэв; 2. танагдах.

ТАНХАЙ 1. зан явдал ёс зүйгээс гажуу, дүрсгүй, даруулгагүй, хүмүүжил муутай, хэрцгий; **танхай балмад** х о р ш.; 2. ажилгүй, сэлгэцэн явах: **танхай явах** (ажил хөдөлмөр хийхгүй дэмий явах).

ТАНХАЙРАХ танхай болох, танхай байдал гаргах, дүрсгүйтэх.

ТАНХАЙРУУЛАХ танхайрахын үйлдүүлэх хэв, танхай болгох.

ТАНХАЙХ үйл үйлдвэр хийхгүй танхайрах; *танхайж хэвтэх.*

ТАНХИ эрх, ардаг, хал үзээгүй, дурааараа аашилдаг, танхид, танхил; **ардаг танхи, эрх танхи** х о р ш.; *танхи өссөн намайгаа, тархий нь эргэтэл загнаад яах вэ* (дуу).

ТАНХИД танхи, танхил.

ТАНХИДАХ хэтэрхий танхи болох.

ТАНХИДУУ танхи байдалтай.

ТАНХИЛ танхи, танхид, ардаг; *ардаг танхил* х о р ш.; *танхил охин.*

ТАНХИЛАХ танхи байдал гаргах.

ТАНХИЛГАН танхил зан байдалтай.

ТАНХИЛЗАХ 1. байдлаа аятай ялгум хийн аашлах; 2. эр эмийн журмыг тэрслэх; 3. эрх танхи байдал гаргах.

ТАХИЛЗУУР 1. танхилзсан байдалтай; 2. эр эмийн журмыг тэрслэгч.

ТАНХИМ 1. х у у ч и р с а н яамлан сууж хэрэг шийтгэх байр; 2. нийтийн хуралдах, цугларах, хичээллэх уудам том тасалгаа; *биеийн тамирын танхим; хичээлийн танхим.*

ТАНШИГДАХ таншихын үйлдэгдэх хэв.

ТАНШИХ 1. гайхам юм үзэж хэл тагнайгаа ташиж дуугаргах; *тагнайгаа танших;* 2. дэмий тэнэн хэсч эрэх; **тэнэх танших** х о р ш.; 3. түргэн долгин хүний ялимгүй чармайх; *таншиж хэлэлцэх.*

ТАНШЛАГА танших үйлийн нэр.

ТАНШУУЛАХ 1. таншихын үйлдүүлэх хэв; 2. таншигдах.

ТАР I 1. хөгширсөн хүн амьтны ид, ир, чадал, танаг; **тар танаг** х о р ш.; 2. авир, байдал зан, чанар; **тар нь танигдах** (муу нь танигдах.)

ТАР II хурдны морийг тарлах нь; *өнөөдөр бага нас тар хийнэ.*

ТАР III: **тар нийлэлцэх, тар нийлэх** аливаа үстийн үс эсэр нийлэлцсэн нь.

ТАР IV: **тар няр хийх** хатуу юмны харшилдан дуугарах чимээ; *мод чулуу тар няр хийв; тар няр хийж унах;* **тар түр хийх** (бага зэрэг хэрэлдэх, маргалдах).

ТАР V тарга.

ТАРААГДАХ тараахын үйлдэгдэх хэв.

ТАРААЛГАХ 1. тараахын үйлдүүлэх хэв; 2. тараагдах.

ТАРААЛТ тараах үйлийн явц; *хэвлэл тараалт; сонин тараалт.*

ТАРААХ 1. тарахын үйлдүүлэх хэв, тарахад хүргүүлэх; *хурал тараах;* 2. тархай болгох; *өвс тараах;* 3. түгээх, хүрэлцүүлэх; *сонин сэтгүүл*

тараах; 4. дэлгэрүүлэх; *зар тараах; цуу уг тараах; өвчин тараах.*

ТАРАГ сүүг исгэж хийх нэгэн зүйл цагаан идээ; *чихэртэй тараг; хонины тараг; үнээний тараг;* **тараг бүрэх** (тараг хийх); **таргийн хөрөнгө** (тараг бүрэхийн тул шүүж авсан тараг).

ТАРАГЛАХ хавар тараг сая гарах; *тэднийх тарагласан байв.*

ТАРАЙЛГАХ тарайхын үйлдүүлэх хэв.

ТАРАЙХ тэрийх, дөрвөн мөчөө сарвайлгаж тэлэн жийж хэвтэх; *тавтайхан тарайж хэвтэжээ үү, чи?*

ТАРАМДАХ хэтэрхий таруу болох.

ТАРАМДУУЛАХ тарамдахын үйлдүүлэх хэв.

ТАРАНГИ тархай байдалтай.

ТАРАНГИДУУ арай таранги, нилээд таранги.

ТАРАНГУЙ тархай, тархай байдалтай.

ТАРАХ 1. зүг, зүг тийшээ явах, одох, сарних, тархай болох; *тарж бутрах; хонь тарж одов;* 2. хурал мэт олны хуралдсан нь дуусах, төгсөх, гүйцэх; *ажлаасаа тараад гэртээ харьж ирэв; хурал тарах; ажил тарах цаг болов;* 3. түгэх, дэлгэрэх; *цуурхал тарах; халдвар тарах.*

ТАРВАГА (Н) амьтан өвөл ичдэг, нэг зүйл мэрэгч амьтан; *тарвага агнах; тарвагаяны арьс;* **тарваган тахал** (хүн ба мэрэгчинд тохиолдох сочмог халдварт тахал өвчин; *тарваган тахлыг эсэргүүцэх станц*); **тарваган шийр** (а. ургамал нийлмэл цэцгийн язгуурын олон наст ургамал, эмнэлэгт хэрэглэнэ; б. мөнхүү ургамлаар хийсэн эм).

ТАРВАГАЦАА тарвага болж тоглох хүүхдийн тоглоом.

ТАРВАГАЦААХ хүүхдийн тоглоом, нэг нь чоно, бусад нь тарвага болж наадна; *тарвагацааж тоглох.*

ТАРВАГАЧИН тарвага агнагчид.

ТАРВАГАЧЛАХ тарвага агнахаар явах.

ТАРВАЛЗАХ сарвалзах.

ТАРВАС ургамал гуагийн төрлийн нэг наст ургамал, үр жимс нь том бөөрөнхий, чихэр амттай, шийгуа; *тарвас тарих.*

ТАРГА таргалах нь; **тарга тэвээрэг** хорш.; *энэ жил малын тарга сайн; тарга авах.*

ТАРГААГ тархнаг.

ТАРГАДАХ хэтэрхий тарган болох.

ТАРГАЛАХ тарган болох; *өвс сайтай газар мал таргалж байна.*

ТАРГАЛЖ амьтан зуны цагт ирдэг, хөхөвтөр өнгөтэй нэг зүйл бялзуухай.

ТАРГАЛУУЛАХ таргалахын үйлдүүлэх хэв.

ТАРГАН 1. идэш тэжээл сайн учраас өөхөлж бүдүүрсэн нь; **тарган цагалан, баян тарган** хорш.; *тарган шар; тарган адуу;* **тарган орох** (өвлийг мал тарган туулах); 2. өөхтэй; *тарган мах.*

ТАРГИЛ усны гүйхэн болоод урсгал нь түргэн газар; *усны таргилыг дагаж гатлахад аятай байдаг.*

ТАРИА (Н) 1. тарьж ургуулах амуу будааны нийтийн нэр; *тариа тарих;* **тарианы газар** (тариа тарих газар): **тарианы талбай** (тариа тарьсан газар); **тариа хураах цаг** (тариа гүйцэд боловсрох хугацаа); **тариа тэгшдэх** (тариа цөм түрүүтэх); **тариа хадах** (тариаг хадуураар хадаж унагаах); **тариа цайлгах** (тариаг ишг, ааг, хальснаас салгах); **тарианы ааг, хивэг** (тарианы хальс); **тариа авах** (тариа хураах); **тариа алдах** (тариа авч чадахгүй болох); 2. зүүтэй шүршүүлээр арьс махны завсар ба булчин эсвэл судсанд хийх эмийн зүйл, тарилга ч гэдэг; *тариа хийх;* **амь тариа** (зүрхний тариа).

ТАРИАЛАН 1. тариа ногоо тарих газар; *тариалантай нутаг;* 2. тарьж ургасан ургамал; *алтан шаргал тариалан миньтүүний дэнжээр халиуранхан байна* (дуу); *тариалангийн орон; тариалангийн багаж; тариалангийн кампани; тариалангийн ажил;* **тариалан хөөгч** (царцааны өөр нэр).

ТАРИАЛАХ тариа тарих, тариалан тарих.

ТАРИАЛУУЛАХ тариалахын үйлдүүлэх хэв.

ТАРИАТАЙ 1. тариа бүхий; 2. тарилга бүхий.

ТАРИАЧИН тариалангийн ажил эрхлэх хүн; *тариачны хүү; тариачны гаралтай; тариачны амьдрал; тариачны хөдөлгөөн.*

ТАРИГДАХ тарихын үйлдэгдэх хэв.

ТАРИЛГА 1. тарих үйлийн нэр; *хаврын тарилга эхлэх болжээ;* 2. тарих эмнэлэг; *цэцгийн тарилга; урьдчилан сэргийлэх тарилга.*

ТАРИМАЛ тарьсан, тарьж ургуулсан, зэрлэг биш; *таримал ногоо; тарималжимс.*

ТАРИУЛАХ 1. тарихын үйлдүүлэх хэв; 2. таригдах.

ТАРИХ 1. ургамал буюу ургамлын үрийг ургуулахаар газарт булах; *ногоо тарих; мод тарих;* 2. ш и л ж с э н халдварлуулах, халдвар тараах; *өвчин тарих;* 3. хэрэг дэгдээх, үүсгэх; *ямар хэрэг тарьж орхиод яваа хүн бэ, чи чинь?* 4. эмийн зүйлийг зүү бүхий шүршүүлээр арьс махны завсар буюу судсанд хийх; *судсанд тарих; булчинд тарих; пенициллин тарих.*

ТАРЛАГЧ (ИН) тарлан эмэгчин; *тарлагч үнээ.*

ТАРЛАН алаг, эрээн, алаг цоохор; **шар тарлан** (шар алаг); *алаг тарлан болох;* **газар тарлан болох** (цас хайлж газар цоохордох).

ТАРЛАНДАХ хэтэрхий тарлан болох.

ТАРЛАНТАХ тарлан болох, эрээн цоохор болох; *цас хайлж, уулын өвөр тарлантаж байна.*

ТАРЛАНТУУЛАХ тарлантахын үйлдүүлэх хэв.

ТАРЛАХ I үсэргэх, уралдахаар уяж байгаа морийг өдөр тутам ойр газар дасгаж давхинулах; *морь тарлах.*

ТАРЛАХ II аливаа юмыг төлөвлөн гаргах.

ТАРМАГ сийрэг, тархай, энд тэнд байгаа, чигжүү биш, таруу; **армаг тармаг** х о р ш.; *тармаг мод.*

ТАРМАГДАХ 1. тармахын үйлдэгдэх хэв; 2. хэтэрхий таруу болох.

ТАРМАХ тармуураар хамах, *өвс тармах.*

ТАРМУУЛ тармуур.

ТАРМУУЛАХ тармахын үйлдүүлэх хэв.

ТАРМУУЛДАХ тармуурдах.

ТАРМУУЛДУУЛАХ тармуулдахын үйлдүүлэх хэв; тармуурдах.

ТАРМУУР өвс хамах хэрэгсэл; *морин тармуур; гар тармуур.*

ТАРМУУРДАХ тармууpаар хамах, тармуулдах.

ТАРМУУРДУУЛАХ тармуурдахын үйлдүүлэх хэв, тармуулдуулах.

ТАРНИ буддын шашны ёсны уншлага залбирлын ном; *тарни урих; тарни унших.*

ТАРНИДАХ тарни урьж үлээх.

ТАРНИДУУЛАХ тарнидахын үйлдүүлэх хэв.

ТАРНИХ торних, өсөх; *хүүхэд тарних.*

ТАРНИЧ шашны ёсны тарни урьж бүтээгчид.

ТАРНИЧЛАХ тарни уншиж бясалгах.

ТАРТАЙ хөгширсөн хүн амьтны идтэй, иртэй, чадалтай; *тартай хөгшин; мал тартай байна; тарчиг залуугаас тартай хөгшин* з ү й р.

ТАРУУ тархай, тарсан нь; *хонь таруу бэлчиж байна; таруу байгаа адуу; таруу мод.*

ТАРХААХ тархахын үйлдүүлэх хэв, тархахад хүргүүлэх.

ТАРХАЙ сийрэг, тарсан, таруу; **тархай бутархай** х о р ш..

ТАРХАХ тарах.

ТАРХИ 1. гавлын дотор байх төв мэдрэлийн тогтолцооны эрхтэн болох эд; *ураг тархи;* **тархи хөдлөх** (ойчих, доргих зэргээс тархи гэмтэх); 2. ш и л ж с э н оюун ухаан; *тархитай хүү;* 3. дээрэнгүйлэх, зандрах үг; 4. сүх мэт багажийн ирийн нөгөө этгээдийн зузаан тал; *сүхний тархи;* ☆ **тархин чулуу** (улаан, улаан шар өнгөтэй нэг зүйл эрдэнийн чулуу).

ТАРХИГҮЙ I төрхгүй, дүрсгүй, зүггүй, томоогүй; *тархигүй жаал.*

ТАРХИГҮЙ II ухаан муутай, мангуу, тэнэг.

ТАРХИДАХ бусдыг тархи гэж харааж зандах; *давааны цаанаас тархидах* з ү й р.

ТАРХИДУУЛАХ 1. тархидахын үйлдүүлэх хэв; 2. тархидагдах.

ТАРХИЛАХ 1. эзэрхэх, түрэмгийлэх, ноёлох, ноёрхох; 2. даалуу мэтээр нөадахад мод гүйлгэхийг боож амдах талд нь суух; *тархилж суух.*

ТАРХМАЛ тархсан юм; *тархмал өвчин; тархмал үг.*

ТАРХНАГ бууны хонгионы дотоодод дарь тавих газар.

ТАРХУУ тарууг, тархай.

ТАРЧ тарвага бозлог **зэргийн** амьтны гурван нас хүрсэн эм нь.

ТАРЧИГ хүн малын идэш ууш ховор; *өвс ногоогоор тарчиг байна; тарчиг цаг; тарчиг хоол; хаврын тарчиг үед.*

ТАРЧИГДАХ тарчиг болох.

ТАРЧИГДУУЛАХ тарчигдахын үйлдүүлэх хэв.

ТАРЧИГНАХ олон тэрэг явах, мал үргэх зэрэгт гарах чимээ; *жагсаал дээр олон танкийн гинжний дуу тарчигнаж байв.*

ТАРЧИГНУУЛАХ тарчигнахын үйлдүүлэх хэв.

ТАРЧИГНУУР 1. тарчигнаж дуугарах хэрэгсэл, тоглоом; 2. хөнгөн тогтворгүй хүн; *тарчигнуур хүн.*

ТАРЧИЛГАХ тарчлахад хүрүүлэх, зовоох, тарчлуулах.

ТАРЧЛААХ тарчлахад хүрүүлэх.

ТАРЧЛАХ ихэд зовох, зүдэх, шаналгах; *зовж тарчлах; колонийн гинжинд тарчлан зовж байжээ.*

ТАРШИХ ярихад хоолой чарагдаж янз янз дуу гарах; *хоолой тарших.*

ТАС I амьтан бүргэдийн намын, сэг идэх махчин том шувуу; **тасын булга** (тасын хөөмий); **тасын хөөмий** (тасын элэг гэдэс хээлүүрийн арьс); **тасын хүж ургамал** (гол төлөв нуга, тал бэл, энгэр газраар ургана, ишний оройд бөөгнөрч байрласан жижиг цэнхэр цэцэгтэй ургамал, төрөл зүйл олон).

ТАС II хүч нэмэгдүүлэх үг; 1. тасартал, салтал, бүрмөсөн; *тас огтлох; тас хазах; тас хяргах; тас хөрөөдөх; тас хайчлах;* 2. нэвширтэл, хаширтал, олигтойхон; *тас алгадах; тас цохих; тас тэврэх; тас загнах; тас шүүмжлэх;* ☆ **тас хар** (пад хар, хав хар).

ТАС III хатан, шууд, эсрэг; *тас зөрөх; тас зөрүү; тас хориглох; тас гүжирдэх; тас мэлзэх; ор тас гүтгэх; тас гэдрэгээ унах;* ☆ **тас өөр, тас мөртөө** (огт адилгүй, шал өөр); **түс тас** (шулуун шудрага).

ТАС IV хүчтэй дуугарах чимээ; *тас няс хийх; тас хийх; тас буух; буу тас хийв; дарь тас хийж дуугарав.*

ТАСАГ 1. албан, үйлдвэрийн газрын дотоод хувиар, хэсэг; **хэлтэс тасаг, тасаг цех** хор ш.; *дэлгүүрийн бэлэн хувцасны тасаг;* **сүүний тасаг** (сүү хүлээн авах, боловсруулах газар); **модны тасаг** (модоор юм юм хийх газар); 2. цэргийн зохион байгуулалтын хамгийн бага хувиар, салааны хэсэг; *тасгийн дарга;* ☆ **тасаг нясаг** (үе үе хэсэг хэсэг).

ТАСАЛБАР I дуусалт, төгсөлт; *тасалбар болгох хэрэгтэй.*

ТАСАЛБАР II тасалсан хэсэг, ямар нэгэн бичгийн таслан авч болох хэсэг нь; *чекний тасалбар; тасалбар дэвтэр.*

ТАСАЛБАРЛАХ 1. тасалбар болгох; таслах.

ТАСАЛГАА 1. тасалсан газар; *энд нэг тасалгаа хийсэн байна;* 2. байшингийн доторхи өрөө, нэгэн хэсэг нь; *том тасалгаа; олон тасалгаатай байшин; унтах тасалгаа.*

ТАСАЛДАЛ тасалдах үйлийн нэр.

ТАСАЛДАХ 1. нийлүүлэх залгуулах зүйл хааяа зогсох, болих, тасрах; *дэлгүүрт талх тасалдаж ирэх болов;* 2. тогтмол байнга хийх юмыг орхигдуулах; *хичээл тасалдах; дугуйлан тасалдах;* 3. эс биелэх; *төлөвлөгөө тасалдах;* 4. дундаа үе үе зогсох, тасрах; *дуу тасалдах.*

ТАСАЛДУУЛАХ тасалдахын үйлдүүлэх хэв; *унаа тасалдуулах; төлөвлөгөө тасалдуулах.*

ТАСАМ I эмжээр, хөвөөлж оёсон зүйл; *дээлийн тасам.*

ТАСАМ II буга, гөрөөсний арьсны зоогоор хийсэн сур.

ТАСАМДАХ эмжих, тасмаар хөвөөлж оёх; *тэрлэг тасамдах.*

ТАСАМДУУЛАХ тасамдахын үйлдүүлэх хэв.

ТАСАРХАЙ 1. тасарсан юм; *цаасны тасархай; дээсний тасархай;* 2. онцгой, салангад; *олноос тасархай хүн; бор морь ижлээсээ үргэлж тасархай явах болов;* **яс махны тасархай** (садан, төрөл; *бидний яс махны тасархай*).

ТАСГИМ: тасгим хүйтэн маш хүйтэн; *өвлийн тасгим хүйтэн.*

ТАСДАХ 1. тасархай болгох; *дундуур нь тасдах; тасдаж хаях;* 2. хэсэглэх, хувааж салгах, таслах; *гурил тасдах; сүрэг хониноос нэг хэсгийг тасдаж авчээ.*

ТАСДУУЛАХ тасдахын үйлдүүлэх хэв.

ТАСЛАГА таслал.

ТАСЛАГДАХ таслахын үйлдэгдэх хэв.

ТАСЛАЛ гох мэт хэлбэртэй нэгэн зүйл цэг тэмдэг, таслага; *таслал тавих; таслал цэг; цэгтэй таслал.*

ТАСЛАЛГҮЙ 1. эс тасалсан, таслаагүй; *ажлаа таслалгүй суралцсаар байв;* 2. таслал, таслагагүй; *цэг таслалгүй.*

ТАСЛАХ таслахын үйлдүүлэх хэв, тасдах; *утас таслах; чангааж таслах; уяа таслах;* ☆ **амь таслах, гол таслах** (алах, нядлах); 2. зогсоох, болиулах; *дипломат харилцаа таслах;* **үг таслах** (ярьж байхад нь зогсоож хажуугаас ярих); 3. байнга хийх зүйлийг орхигдуулах; *өдөр тутам өгөх эмийг тасалж үл болно; хичээл таслах;* 4. үл биелүүлэх; *төлөвлөгөө таслах;* **ажил таслах** (а. даалгасан ажил үл биелүүлэх; б. тогтмол ажилд үл ирэх); 5. нэгэн тийш болгох; *хэрэг таслах; таслан шийтгэх; зарга таслах; хэрүүл таслах; маргаан таслах;* 6. байнга залгуулах, нийлүүлэхийг болих, зогсох; *махаар таслах; сүүгээр таслах.*

ТАСЛУУЛАХ 1. таслахын үйлдүүлэх хэв; 2. таслагдах.

ТАСРАЛ барагдал, дуусал, төгсөл.

ТАСРАЛГҮЙ дуусгалгүй, зогсголзохгүй, байнга, үргэлж; *гаднын хүмүүс тасралгүй цувж байв.*

ТАСРАЛТ тасрах үйлийн нэр; **зогсолт тасралт** х о р ш..

ТАСРАЛТГҮЙ цаг үргэлжид, байнга, тасралгүй; *тасралтгүй ажилласаар байв*

ТАСРАХ 1. тасархай болох; *холбоо тасрах; дээс тасрах; уурганы хуйв тасарчээ;* ☆ **гол тасрах** (үхэх; *гол тасартал горьдлого тасрахгүй* з ү й р; **гэгээ тасрах** (харанхуй болох); 2. байнга тогтмол хийдэг юмыг үл хийх; *хичээл тасрах; хурал тасрах;* 3. үл биелэх; *төлөвлөгөө тасрах; ажил тасрах;* 4. нэгэн тийш болох, барагдах; *хэрэг нь тасрах; хоёр тасарч хөдлөх;* 5. нийлүүлэх, залгуулахыг болих, зогсох; *сүү тасрах; түлээ тасрах;* 6. хуваагдах, анги анги болж салах, сураггүй болох; *чимээ тасрах.*

ТАСРАШГҮЙ 1. тасрахуяа бэрх, үл тасрах; 2. үл тасалдах, байнга үргэлжлэх; *тасрашгүй олон хурал болдог байв.*

ТАСРУУЛАХ тасрахын үйлдүүлэх хэв.

ТАСХИЙМ: тасхийм хүйтэн тасгим.

ТАТААЛ 1. усны суваг; **татаал суваг** х о р ш. 2. усыг урсган авачих хоолой, мөр; *хотын усны татаал.*

ТАТААС (АН) ямаа зөөр зэргийн элдсэн нимгэн арьсаар нарийн зүссэн оосор; *татаасан хэлхээ; татаасан оосор.*

ТАТАГ татуу, мөчиг; **татаг мөчиг** х о р ш.;

ТАТАГДАХ 1. татахын үйлдэгдэх хэв; *салхины хүчинд татагдан хөдлөх;* 2. өртөх, чирэгдэх; *хүний хөмрогонд татагдах;* 3. хэрэгт холбогдох; *хэрэгт татагдах;* 4. дайчлагдах; *цэрэгт татагдах.*

ТАТАЙ тэнхээгүй хүнийг шоодох үг .

ТАТАЙЛГАХ татайхын үйлдүүлэх хэв, татгар болгох.

ТАТАЙХ хувцас, бүрээс зэргийн давчуу, явцуу болох, багадах; *дээл нь татайгаад өмсөх аргагүй болжээ.*

ТАТАЛ I ном зохилын санаа зорилтыг хураангуйлан гаргаж уг зохилын өмнө хийсэн оршил биш товч өгүүлбэр.

ТАТАЛ II татлага.

ТАТАЛГАХ бичиг үгийг хурдлан бичих тэмдэглэх; *таталгах бичгийн журам; таталган бичих; таталган бичээч.*

ТАТАЛДАХ 1. татганах, татав татав хийх, байн байн татах, гатвалзах; *таталдан унах;* **таталдах өвчин** (булчин шөрмөс хүчтэй татах халдварт өвчин); 2. хувцас мэтийн оёдол татаж хунирах, үрчийх; *дотор нь богинодсон учир хормой нь таталдаж байна.*

ТАТАНХАЙ 1. гүйцэд тэнийж эс чадах; *татанхай хөл;* **татанхай халанхай, өрөөл татанхай** х о р ш.; 2. ш и л ж с э н харамч, харуу; **татанхай гартай** (харамч).

ТАТАРГАХ татрахын үйлдүүлэх хэв, татруулах.

ТАТАХ 1. үгтээх, чангаах; *гадагш нь татах; чанга татах; нум татах; моринь амыг татах; олом татах;* **эсгий татах** (эсгий чирч боловсруулах); **өрх татах** (өрхийг гэдрэг нь сөхөх); 2. даруулан бэхэлж хүлэх; *ачаа татах; чангахан татаарай алдуурна шүү!* 3. олс, дээс мэтийг хэцлэх, тэлж бэхлэх; *утас татах; хэц татах;* **зэл татах** (мал уях зэл сунгаж бэхлэх; *гүүн зэл татах; тугалын зэл татах*); **дээс татах**

(хөл хорих); 4. мөч, эрхтэн тэнийхгүй болох, татганан хөдлөх, татганах; *хөл татах; нүд татах*; *баруун нүдний дээд зовхи байн байн татаад байна хөө хөө* (дуу); **цорой татах** (ходоод гэдэсний дотор сүрхий өвдөх); **шөрмөс татах** (булчин өөрөө хүчтэй агчин татаж сүрхий өвдөх); **хэл татах** (хэлж чадахгүй болох); 5. суваг татаал малтах; *суваг татах; шуудуу татах*; 6. мах, ногоо зэргийг маш жижигхэн хэрчиж огтлох; *мах татах; ногоо татах;* 7. ямар нэгэн сэлбэг оруулах, өнгө хийх; *гуталд толгой татах*; *уурганд үзүүр татах; дээлд өнгө татах;* 8. амьсгал хий мэтийг дотогш оруулах, сорох; *амьсгал татах*; *тамхи татах; хамрын тамхи татах*; *яндан сүрхий татаж байна;* 9. хураах авах, хумих; эмхлэх; ойртуулах; *задгай орхисон юмаа татаж авах*; *уулнаас түлээ татах; өөрлжөөндөө өвс татаж авах;* 10. хөгжмийн зэвсгийг үлээх, дуугаргах; *лимбэ татах*; *бүрээ татах*; *хуур татах;* 11. татварлах, дайчлах; *алба татах*; *цэрэг татах; тээвэрт хөсөг татах; хэрэгт татах*; *татаж байцаах;* 12. сайн буюу муу явдал уруу оруулах; **өөд татах** (амь юмыг засч эмхлэх; *өөрийн юм байна, өөд татаад авъя*; 6. сайн замд удирдах, сайжруулах; *ажил нь далан задгай байсан юм, дарга ч амархан өөд татлаа шүү дээ*); **уруу татах** (алив үйл явдалд муугаар нөлөөлөх, дордоох; *хүүхэд битгий уруу татаад байгаарай!*); 13. аливаа юмыг өөрийн зүг хандуулах, хань хамсаа болгох, *дур татах; сэтгэл татах; сонирхол татах;* **хань татах** (ганцаардахаас болгоомжлох); **нөхөр татах** (аливаа хэргийг хамт өдүүлсэн хийсэн гэж хань болгох); **тал тохой татах** (бусдаас урьдал болгож үзэх, танилаа дотнолон үзэх); 14. түгэх, тархах, халхлах; *манан татах; униар татах; хөшиг татах* 15. жин дарах; *энэ шар гурван зуун кило татаж байна;* ☆ **солонго татах** (солонго гарах); **ус татах** (үерлэсэн, түрсэн ус бага болох): **гэдсээ татах** (гэдсээ эвхийн нарийн болгох); **амаа татах** (илүү үг хэлэхгүй байх); **үнэ татах** (үнэ саах, бууруулах); **татан буулгах** (албан газар мэтийг албан ёсоор үгүй болгох). ᠲᠠᠲᠤᠬᠤ

ТАТАШ I хөшиглөсөн махтай хоол; *таташ идэх.* ᠲᠠᠲᠠᠰᠤ

ТАТАШ II морь малын харайлга; *таташ холтай.*

ТАТВАЛЗАМТГАЙ татвалзах зантай. ᠲᠠᠲᠪᠠᠯᠵᠠᠮᠲᠭᠠᠢ

ТАТВАЛЗАХ татганах, чазвалзах; *нүд ам татвалзах; гар хөл татвалзах.* ᠲᠠᠲᠪᠠᠯᠵᠠᠬᠤ

ТАТВАЛЗУУЛАХ татвалзахын үйлдүүлэх хэв. ᠲᠠᠲᠪᠠᠯᠵᠠᠭᠤᠯᠬᠤ

ТАТВАЛЗУУР 1. татгалзуур, татгалзах зантай; 2. татвалзамтгай. ᠲᠠᠲᠪᠠᠯᠵᠠᠭᠤᠷ

ТАТВАР I татварлаж авах зүйл, оноож авах зүйл; *ашиг орлогын татвар хасагдав;* **алба татвар, албан татвар** (ард иргэдээс улсад гувчуурлан авах зүйл); **гишүүний татвар** (сайн дурын байгууллагад гишүүдээс оруулах мөнгө); **татварын хууль** (татварлан авах тухай гаргасан хууль); ☆ **татвар эм хуучирсан** (багахан гэргий). ᠲᠠᠲᠪᠤᠷ

ТАТВАР II цус холилдсон мал.

ТАТВАРЛАХ татвар авах, албан татвар оногдуулах; *ард иргэдээс татварлах.* ᠲᠠᠲᠪᠤᠷᠯᠠᠬᠤ

ТАТВАРЛУУЛАХ татварлахын үйлдүүлэх хэв. ᠲᠠᠲᠪᠤᠷᠯᠠᠭᠤᠯᠬᠤ

ТАТГАЛЗАЛ татгалзах үйлийн нэр, татгалзвар. ᠲᠠᠲᠭᠠᠯᠵᠠᠯ

ТАТГАЛЗАМ татгалзмаар. ᠲᠠᠲᠭᠠᠯᠵᠠᠮ

ТАТГАЛЗАХ 1. үл зөвшөөрөх; *зөвшөөрөхгүй татгалзах; татгалзах саналтай байх; би татгалзана;* 2. басхүү сэжиглэн санагалзах. ᠲᠠᠲᠭᠠᠯᠵᠠᠬᠤ

ТАТГАЛЗВАР татгалзал. ᠲᠠᠲᠭᠠᠯᠵᠤᠷ

ТАТГАЛЗВАРТАЙ татгалзах зүйл бүхий. ᠲᠠᠲᠭᠠᠯᠵᠤᠷᠲᠠᠢ

ТАТГАЛЗУУЛАХ татгалзахын үйлдүүлэх хэв. ᠲᠠᠲᠭᠠᠯᠵᠠᠭᠤᠯᠬᠤ

ТАТГАЛЗУУР татгалзах, тээнэгэлзэх зан байдалтай; *тэр ч болдоггүй татгалзуур хүн.* ᠲᠠᠲᠭᠠᠯᠵᠠᠭᠤᠷ

ТАТГАНАХ татвалзах, таталдах; *татганан хөдлөх.* ᠲᠠᠲᠭᠠᠨᠠᠬᠤ

ТАТГАНУУЛАХ татганахын үйлдүүлэх хэв. ᠲᠠᠲᠭᠠᠨᠠᠭᠤᠯᠬᠤ

ТАТЛАА татах зүйл, саад, садаа; **татлаа түлхлээ** (араас татаж саад болох зүйл). ᠲᠠᠲᠯᠠ

ТАТЛАГА I ачсан ачааг бэхэлж хүлэх бөх оосор; *ачааны татлага.* ᠲᠠᠲᠯᠠᠭ

ТАТЛАГА II дайчлан татах үйлийн нэр; **дайчлага татлага** хор ш.; *цэрэг татлага.*

ТАТЛАГАЛАХ юмыг татлага оосроор даруулан бэхлэх, хүлэх; *ачаагаа сайн татлагалаарай.* ᠲᠠᠲᠯᠠᠭᠠᠯᠠᠬᠤ

ТАТЛАХ I 1. байн байн татах; 2. саад тотгор болох, саатуулах; **татлах түлхлэх** хор ш.. ᠲᠠᠲᠯᠠᠬᠤ

ТАТЛАХ II таталгах; *таталж бичсэн бичиг.*

ТАТЛУУЛАХ татлахын үйлдүүлэх хэв.

ТАТМАЛ татаж хийсэн юм; *татмал ус*; *татмал суваг*; **татмал бурам** (чанасан бурам).

ТАТРАХ бага болох, ховор болох, багасах, хорогдох; *сааль татрах; бороо татрах; хөл хөдөлгөөн татрах;* **ус татрах** (ус бага болох).

ТАТРУУЛАХ татрахын үйлдүүлэх хэв.

ТАТУУ I. хэмжээгээр арай гүйцэхгүй, дутуу арай хүрэхгүй; *хатуу жигнэх; нэг тал нь татуу;* 2. багавтар; *гол татуу байна.* 3. шилжсэн харуу, харам, харамч; *чи битгий татуу зан гаргаад бай;* **гар татуу** (харамч)

ТАТУУДАХ хэтэрхий татуу болох.

ТАТУУДУУЛАХ татуудахын үйлдүүлэх хэв.

ТАТУУР I 1. шургуулга; **татуур ширээ** (шургуулгатай ширээ); 2. элдэв татаж хэрэглэх зүйлс; **татуур онгоц** (маш хөнгөн бага онгоц); **татуур өөш** (загас агнах зэвсэг); **татуур хутга** (ирийг матруулан хийсэн хутга); **татуур шугам** (модонд шугам татах зэвсэг); **татуур дээж** (мөрийгөөс багатгаж авах юм).

ТАТУУР II хуучны эхнэр хүний толгойн хэрэгсэл, мөнгө зэргээр хийсэн тоорцог мэт чимэг.

ТАТУУР III татуурга.

ТАТУУРАХ татрах, татуу болох; *ус татуурах; хур татуурах.*

ТАТУУРГА I ширээ шүүгээний шургуул.

ТАТУУРГА II татах, чирэх оосор сэнж.

ТАТУУРГА III өх голоосоо салж урссан нарийн салаа; *Сэлэнгийн татуурга гүнзгий шүү!*

ТАТУУРУУЛАХ татуурахын үйлдүүлэх хэв.

ТАХ I морь тэмээ зэргийн туурай таваг, гутлын ул зэрэгт бэхэлж хадах төмөр, шир; *морины тах; гутлын тах; тах хадах.*

ТАХ II амьтан мөрөн голд байдаг, том моголцог толгойтой, нарийн хайрстай, тэгш хушуутай загас, дотроо гурван зүйл бий.

ТАХАЛ ямар нэгэн өргөн түгэх халдварт өвчин; **өвчин тахал** хорш.; *тахал дэлгэрэх.*

ТАХАЛТАХ тахал өвчин тохиолдох.

ТАХАЛТУУЛАХ тахалтахын үйлдүүлэх хэв.

ТАХАРВАР амьтан барстай адил болоод өнгө хар нэг зүйл амьтан.

ТАХГҮЙ тах тавиагүй; *тахгүй морь.*

ТАХИА I. тэжээвэр нэгэн зүйл шувуу; *эр тахиа; тахианы мах; тахианы өндөг;* 2. сарны зурхайн ёсны арван хоёр эрхтэний аравдугаар нь; *тахиа жил;* **тахианы хонуурь** (тахианы хоноглох орон); **тахианы өндөгний зоог боорцог** (дутрага амууны гурилд тахианы өндөг, бал, чихэр хоршиж, хушганы цөмийн идээ хийгээд гахайн тосонд буцалгасан идээ); **тахиан тардь** амьтан (гардийн өөр нэр, янз том тахиатай адил); **тахианы цэцэг** (а. ургамал өвсөн иштэй, ишний үзүүрт тахианы цэцэгтэй адил цэцэг цэцэглэдэг, сарвалж ногооны адил навчтай, зүйл бүрийн өнгөтэй ургамал; б. тахианы толгой дээр ургасан улаан цэцэг мэт зүйл).

ТАХИГАР тохигор өндөр, махигар, тахир; *тахигар уурга; тахигар төмөр.*

ТАХИГДАХ тахихын үйлдэгдэх хэв.

ТАХИГЛАХ тахих, тайх, өргөх.

ТАХИЙЛГАХ тахийхын үйлдүүлэх хэв, тахигар болгох.

ТАХИЙХ тахир болох, матирах, муруйх; *тахийсан хадаас.*

ТАХИЛ шашны ёсонд: тайх тавиглахад зориулан хэрэглэх зүйл; *тахил тавих; тахил өргөх; тахилын цөөц; тахилын цэцэг.*

ТАХИЛАГ гуйванга шувуу.

ТАХИЛГА тахих үйлийн нэр; **тайлга тахилга** хорш.; *уулын тахилга; овооны тахилга.*

ТАХИЛГАЛАХ тахилга үйлдэх.

ТАХИЛЗАХ тахигар юмны байн байн тахийх, нахилзах, гулзганах; *тахилзсан нарийн бургас; урт уурга нь тахилзаж байв.*

ТАХИЛЗУУР шаант чөмөгний зэрэгцээд байх нарийн яс, тэр орчны газар; *тахилзуураар өвдөх.*

ТАХИЛЧ тахил тавиглал эрхлэгч хүн.

ТАХИМ I хүн малын тойгийн тус нугарах үе газар.

ТАХИМ II бөхийн барилдаанд давсан бөх, давсны дараа үнасан бөхтэйгөө тэврэлдэж давсан давагдсанаа батлахы нь; **тахим авах** (а. бөхийн мэх, тахимаас шүүрэн барих; б. давсан давагдсанаа баталж тахим өгөх).

ТАХИМДАГДАХ тахимдахын үйлдэгдэх хэв.

ТАХИМДАХ I тахимаас шүүрэх, бөхийн мэх.

ТАХИМДАХ II ачлах, элбэрэх, тахимдуу байдал үзүүлэх.

ТАХИМДУУ ачлалтай, элбэрэлтэй; *эцэг эхдээ тахимдуу үр хүүхдийг хажуунаас харахад бахдалтай.*

ТАХИМДУУЛАХ 1. тахимдахын үйлдүүлэх хэв; 2. тахимдагдах.

ТАХИМЛАГ аяга тахимлаг.

ТАХИР махир, муруй; **муруй тахир** х о р ш.; *тахир мод; тахир гол.*

ТАХИРАХ I ёнхор утас мэтийн эрчит юмны ширэлдэх, бөөгнөрөх.

ТАХИРАХ II тахир болох.

ТАХИРЛАХ тахир болох, тахийлгах, тахир явах; *зам тахирлан одов; тахирлаж зурах.*

ТАХИРЛУУЛАХ тахирлахын үйлдүүлэх хэв.

ТАХИУЛАХ тахихын үйлдүүлэх хэв.

ТАХИХ 1. тайх, тавиглах, тахил болгож өргөх; 2. шүтэх; **тахих шүтэх** х о р ш.; **нэг хүнийг тахин шүтэх** (нийт олны амжилт бүтээлийг нэг хүнийх болгон хэт итгэж бишрэх магтаж өргөмжлөх).

ТАХЛАХ тах хийх; *гутал тахлах газар; морь тахлах;* ☆ **нүүр тахлах** (найртай хүнд өчүүхэн төдий боловч юм өгөх).

ТАХЛУУЛАХ тахлахын үйлдүүлэх хэв.

ТАХТАЙ тах бүхий; *тахтай морь хатуу газар явахад сайн.*

ТАХЬ а м ь т а н маш ховор болж байгаа зэрлэг адуу.

ТАЦ I угийн шавартай, хуурай болохгүй газар, даац ч гэдэг.

ТАЦ II: **тац мод** у р г а м а л янз байдал моностой адил, түлэхэд маш үсрэмтгий нэгэн зүйл мод.

ТАЧААГДАХ тачаахын үйлдэгдэх хэв.

ТАЧААДАХ тэсч ядах.

ТАЧААЛ юманд хэтэрхий шунан тэсч ядах үйлийн нэр; **хурьцал тачаал, хүсэл тачаал** х о р ш..

ТАЧААЛГАХ 1. тачаахын үйлдүүлэх хэв; 2. тачаагдах.

ТАЧААНГУЙ тачаал, шунахай саная; **шунал тачаангүй** х о р ш..

ТАЧААХ дурлан шунах, шунаж хүсэх; **хурьцах тачаах** х о р ш.; *эд мөнгөнд тачааж шунах; өнгөнд тачаах.*

ТАЧИГ: мөчиг тачиг арай, дөнгөж; *дээлийн өнгө мөчиг тачиг хүрэв; өмсөхөд мөчиг тачиг болж байна.*

ТАЧИГИАХ 1. пажигнан, тас няс хийж дуугарах; *буюны замаг тачигнан дуугарч байв;* 2. ш и л ж с э н хашгиран уурлаж загнах; *манай аав тачигнаж гарав.*

ТАЧИГНУУЛАХ тачигнахын үйлдүүлэх хэв.

ТАЧИР богино, охор, тархай, муу ургасан нь; *тачир өвстэй газар; тачир үстэй арьс; тачир тариалан.*

ТАЧИРДАХ хэтэрхий тачир болох.

ТАЧИРЛАХ тачир болгох.

ТАЧУУ бачуу, бачим, явцуу, мөчиг; *тачуу цамц; тачуу бачим хүн.*

ТАЧУУДАХ хэтэрхий тачуу болох.

ТАЧЬЯАДАЛТАЙ тэсч ядалтай, хорсолтой.

ТАЧЬЯАДАМ тэсч ядам, тэсшгүй; *тачьяадам халуун.*

ТАЧЬЯАДАХ тэсч ядах; *хорсч тачьяадах; даарч тачьяадах; тачьяадтал инээх.*

ТАШАА I худал, хуумгай, хилс, омтгай, эндүү; **худал ташаа, хилс ташаа, омтгай ташаа** х о р ш.; *ташаа хэрэг; ташаа үг; ташаа явдал.*

ТАШАА (Н) II амьтны бэлхүүс, сүүж ясны толгой орчны газар; *ташаагаа тулах; ташаан дээрээ тамгатай;* **ташаан толгой** (сүүжний дээд сэртэн); 2. дээл хувцасны эн нийлэх

газар оруулсан хушуу нарийн оруулга; *дээлийн ташаа; ташаа нь унжуу; өргүү ташаатай дээл.*

ТАШААЛАВЧ 1. балт зөгийн үүрийн доторхи нэгэн өрөө; 2. гэр, оромжийн дотор ташаалж хийсэн өрөө мэт зүйл.

ТАШААЛАГДАХ зайдандах, алсдах; *уул гол ташаалагдан орших.*

ТАШААЛАХ I ташаалавч хийх, хашаа хамар барих, халхлах.

ТАШААЛАХ II цоогчлох, алагчлах, алгасах.

ТАШААЛДАХ 1. ташаа тулах; *ташаалдан зогсох;* 2. дээл хувцсанд хушуу оруулга оруулж хийх зөрүүлдэж хийх; *дээл ташаалдаж хийх; ташаалдаж эсгэх.*

***ТАШААЛУУЛАХ** ташаалахын үйлдүүлэх хэв.

ТАШААРАЛ ташаарах үйлийн нэр; *эндүүрэл ташаарал х о р ш..*

ТАШААРАХ андуурах, эндүүрэх, буруу болох; *та ташаарсан байж магадгүй; ташаарах зүйл алга.*

ТАШААРСХИЙХ баахан ташаарах.

ТАШААРУУЛАХ ташаарахын үйлдүүлэх хэв.

ТАШИЛХИЙЛАГДАХ ташилхийлахын үйлдэгдэх хэв.

ТАШИЛХИЙЛАХ I бусдыг тэнсэн үзэх, тэнсэн турших.

ТАШИЛХИЙЛАХ II 1. үйл явдалд өөрийн дураар дагаж дарвилцах; 2. бусдад ташимгайлан нийлүүлж явах.

ТАШИЛХИЙЛУУЛАХ 1. ташилхийлахын үйлдүүлэх хэв; 2. ташилхийлагдах.

ТАШИМГАЙ бялдууч, зусарч.

ТАШИМГАЙЛАХ 1. бялдуучлах, зусардах; 2. танимгайрхах.

ТАШИМГАЙЛУУЛАХ ташимгайлахын үйлдүүлэх хэв.

ТАШИМГАЙРАХ бялдуучлах, ташимгай болох.

ТАШИРЛАХ зэрэгцэн давхарлах; *таширлан зогсох; гэр таширлах.*

ТАШИУЛАХ ташихын үйлдүүлэх хэв.

ТАШИХ 1. ташуу болох; *замаас ташиж явав;* **бороо ташиж орох** (бороо хажуугаас жишүү орох); 2 хазгай газар халтиран унах; *ташиж явчуузай, мэдээрэй!;* 3. нар хэлбийх; *нар таших;* 4. чөмөг ясыг хага цохих; *чөмөг таших;* 5. бөхийн мэх, говших; 6. алгыг хооронд нь дэлдэх; *алга таших;* 7. ш и л ж с э н бялдуучлах; *ташиж нийлүүлэх.*

ТАШЛАХ цохолсон юмны дэс дэдэд орох, *цохолсон тэр; ташилсан тэр.*

ТАШЛУУЛАХ 1. ташлахын үйлдүүлэх хэв; 2. дагалдуулах; *захидалд ариун хадаг ташлуулан барив.*

ТАШРАМ ялдар, аянтал, ялдам, далим; *үүний ташрамд нэг зүйлийг хэлэхийг хүснэ; дайралдсан ташрамд; явдлын ташрамыг харах; ташрамын хүнээр хүргүүлэв;* ташрам **хаалга** (чухам хаалганаас гадна ойр дотийг харж тусгайлан хийсэн жижиг хаалга).

ТАШРАМДАХ далимдах.

ТАШРАМДУУЛАХ ташрамдахын үйлдүүлэх хэв.

ТАШРАМЛАХ далимлах.

ТАШУУ хэлбүү, хазгай, жишүү; *уулын ташуу; ташуу газар; ташуу хавтгай; ташуу зам; ташуу шугамтай дэвтэр.*

ТАШУУДАХ хэтэрхий ташуу болох.

ТАШУУЛАХ ташихын үйлдүүлэх хэв.

ТАШУУР морь мал гуядах хэрэгсэл; *хулсан ташуур; суран ташуур; ташуурын сэгэлдрэг; ташуурын сур;* **ташуур хорхой** а м ь т а н (цэнгэг усны өт, амьтны биед наалдаж цусыг сорон амьдрах шавьж).

ТАШУУРАЛ ташуурах үйлийн нэр.

ТАШУУРАХ 1. амарлингүй болох, хайхрамжгүй болох; *жаргалдаа ташуурах;* 2. ужидлах, муу юманд шунах.

ТАШУУРДАГДАХ ташуурдахын үйлдэгдэх хэв.

ТАШУУРДАХ ташууряар жанчих.

ТАШУУРДУУЛАХ 1. ташуурдахын үйлдүүлэх хэв; 2. ташуурдагдах.

ТАЯГ тулж явах хэрэгсэл; *гар таяг; суга таяг; зуу насыг насалж, зургаадай таягийг барьж...* (үлгэрээс).

ТАЯГДАГДАХ таягдахын үйлдэгдэх хэв.

ТАЯГДАХ 1. шидэх, хаях, орхих; *тийш нь таягдаж орхив;* 2. таягаар жанчих.

ТАЯГДУУЛАХ 1. таягдахын үйлдүүлэх хэв; 2. таягдагдах.

ТАЯГЛАХ таяг тулах, таяг тулж явах.

ТАЯГЛУУЛАХ таяглахын үйлдүүлэх хэв.

ТЕАТР ший жүжиг үзүүлэх газар; *их театр; хүүхэлдэйн театр; аймгийн театр; театрын жүжигчин; театрын сургууль.*

ТЕАТРЧ театрын урлагт сонирхогч

ТЕЛЕГРАММ цахилгаан утас.

ТЕЛЕГРАФ 1. цахилгаан хүчний тусламжаар мэдээ сэлтийг алсад дамжуулах хэрэгсэл; 2. цахилгаан мэдээ дамжуулах газар.

ТЕЛЕГРАФЧ цахилгаан мэдээ дамжуулагч мэрэгжилтэй хүн.

ТЕЛЕСКОП тэнгэрийн эрхэс од гаргийг ажиглах гэрэлтлэг багаж.

ТЕЛЕФОН цахилгаан хүчний тусламжаар авиа, үг яриаг алсад дамжуулах хэрэгсэл; *телефон утас; телефон аппарат; телефоны шугам.*

ТЕМПЕРАТУР аливаа юмны халж байгаа хэмжээ, зэрэг.

ТЕННИС жижиг бөмбөгийг хавтгай хэрэгслээр цохиж тор давуулан наадах тоглоом; *ширээний теннис; теннисийн аврага шалгаруулах.*

ТЕОРЕМ тоо бодлогын ухааны баталгаа шаардагдах дүрэм.

ТЕОРИ онол, үзэгдэл, баримт ба түүнд нийтийн ашиг тусын тул нөлөөлөх чадлыг тайлбарлах шинжлэх ухааны ерөнхий зарчмыг гаргах практик туршлагын нэгдэл болох сургаал.

ТЕХНИК 1. аливаа үйлдвэрийн багаж хэрэгслийн цогц, түүнчлэн хүний хөдөлмөрийн бүтээлийг дээшлүүлэхэд чиглэгдсэн **техөөрөмж**; 2. машин, механик багаж, **техөөрөмж**; **машин техник** х о р ш.; *техникийн мэдлэгийг дээшлүүлэх; техникийн шинжлэх ухаан.*

ТЕХНИКУМ алив тусгай мэрэгжлийн болон техникийн дунд боловсролын сургууль; *хүн эмнэлгийн техникум; санхүү-эдийн засгийн техникум; үйлдвэрийн техникум; техникумийн багш.*

ТЕХНИКЧ 1. техникийн дунд боловсролтой мэрэгжилтэн; *сүү тосны заводын техникч;* 2. техникийн шинжлэх ухаан, техникийн салбарт мэрэгжсэн хүн.

ТЕХНОЛОГИ алив материал, түүхий эдийг боловсруулах арга ажиллагааны явцын цогц; *үйлдвэрийн технологи.*

ТЕХНОЛЮГИЧ технологид мэрэгжсэн хүн.

ТИВ далай тэнгэсээр хүрээлэгдсэн асар уудам газар, эх хуурай газар; *Ази тив; таван тивийн шудрага хүмүүс энх тайвны төлөө тэмцэж байна.*

ТИЙ: тий тий даарахад хэлэх аялга; *тий тий, яасан хүйтэн юм бэ!*

ТИЙЗ 1. гарын тэмдэг; *тийз дарах;* 2. х у у ч и р с а н орон нутагт гүйлгээнд явж байсан мөнгөн тэмдэгт.

ТИЙЗДҮҮЛЭХ 1. тийздэхийн үйлдүүлэх хэв; 2. тийздэгдэх.

ТИЙЗДЭГДЭХ тийздэхийн үйлдэгдэх хэв.

ТИЙЗДЭХ тийз дарж битүүмжлэх.

ТИЙЛЭХ морь малын хэвэл татах.

ТИЙМ 1. тэр мэт, тэр янзын, тэр адил; *тийм ном байхгүй;; тийм хүн ирсэнгүй; тийм байж болно; тийм ёс алга; тийм учраас; тиймийм тул;* 2. зөвтгөх, зөв, мөн гэж хариулахад хэрэглэх үг; *чи явсан уу? тийм ээ, би явсан.*

ТИЙМХЭН барагтайхан, муухан, базаахгүй, таарууxан; *тиймхэн хүн; тиймхэн хэрэг болж доо.*

ТИЙМШИГ 1. барагтай шиг; 2. төлөв, барагцаа; *санаа нь тиймшиг л байна.*

ТИЙМЭРХҮҮ 1. адил, төстэй; *яг тиймэрхүү ном байсан;* 2. барагтайхан, таарууxан, базаахгүй; *тиймэрхүү хүн.*

ТИЙН I ийн гэдэгтэй эсрэг уттатай үг; *тийн атал; тийн амьдарч байтал; тийн хүү;* **тийн гэж** (чингэж); **тийн гэвч** (чингэвч).

ТИЙН II: тийн ялгал өгүүлбэр дахь үгийн уттаас шалтгаалан нэр үг, үйлт нэр зэргийг хувилгах хэлбэр.

ТИЙН III: тийн мэдэх ухаж мэдсэнээ сэрэн санах.

ТИЙНХЭН цаашхан.

ТИЙРҮҮЛЭХ 1. тийрэхийн үйлдүүлэх хэв; 2. тийрэгдэх.

ТИЙРЭГ шувуу шавьж зэргийг барих урхи.

ТИЙРЭГДЭХ тийрэхийн үйлдэгдэх хэв.

ТИЙРЭН х у у ч и р с а н шулам, чөтгөр.

ТИЙРЭХ 1. тэмээ, үхэр зэрэг амьтны хойт хөлөөр өшиглөх; *тийрдэг үнээ;* 2. буудахад буу гэдрэг хүчтэй ёврох; *буу тийрэх.*

ТИЙЧИГНҮҮР тийчлэх зантай, тийчлүүр.

ТИЙЧИГНЭХ 1. байн байн тийрэх; 2. тийчлэх.

ТИЙЧИХ байн байн тийрэх.

ТИЙЧЛҮҮЛЭХ тийчлэхийн үйлдүүлэх хэв.

ТИЙЧЛҮҮР тийчигнүүр.

ТИЙЧЛЭХ хөлөөр байн байн тийрэх; *битгий тийчлээд бай!*

ТИЙШ ийш гэдгийн эсрэг утга, тэр зүг өөд; *үүл тийш явсан; барууи тийш! зүүн тийш!*

ТИЙШЭЭ ийшээ гэдгийн эсрэг утга; тэр зүг рүү; *гэр тийшээ явна; би удахгүй, тийшээ яваад ирнэ.*

ТИТЭМ 1. хүндэтгэвэл зохих хүний малгай; *хааны титэм;* 2. хуучин монгол бичгийн А-гийн төрлийн үсгийн толгой ганц шүд; *Э-гээс бусад А-гийн төрлийн үсэг цөм титэмтэй.*

ТОВ I шийдвэр; *товы нь дуулах; хэзээ мордохын тов нь гараагүй байна.*

ТОВ II: **ов тов** энд тэнд; *ов тов цоохор.*

ТОВ III: **тов хийх** шав хийх, овоо, зэгсэн болох; *тов хийсэн юмтай айл.*

ТОВ IV хүч нэмэгдүүлэх үг; *тов тодорхой; тов торниун.*

ТОВ V: **тов хийх** гэнэт санаа хүрэх; *санаанд тов хийтэл оров;* **тов тов хийж санагдах** (тасралгүй санагалзах, байнга санагдах).

ТОВ VI: **тов тов** тог тог хийх чимээ; *товтов алхлан ирэв.*

ТОВГОР овгор, төмбөгөр; **овгор товгор** х о р ш.; *товгор газар.*

ТОВГОРДОХ хэтэрхий товгор болох.

ТОВЖИГНОХ 1. тасалдахгүй түргэн тодорхой хэлэх, ярих; *товжигнотол ярьж байв; товжигнон унших;* 2. тов тов хийж түргэн түргэн явах, алхах.

ТОВИМОЛ товьж хийсэн; *товимол-тоног.*

ТОВИХ төмөрлөгт товойтол цохилж хээ угалз гаргах.

ТОВЛОХ шийдэж тогтох, болзох; *чухам хэдий хирд болохыг товлон хэлэх.*

ТОВОЙЛГОХ товойхын үйлдүүлэх хэв, товгор болгох.

ТОВОЙХ 1. товгор болох, овойх, төмбийх; *товойж харагдах; өвөр дотор нь товойж байв;* 2. ш и л ж с э н шалгарсан; *олны дотроос товойж гарсан хүн.*

ТОВОЛЗОХ товгор юмны товс товс хөдлөх, оволзох; **оволзох товолзох** х о р ш.

ТОВОЛЗУУЛАХ товолзохын үйлдүүлэх хэв.

ТОВРОГ талх, хэмхдэг; *товрог болгох;* **тоосон товрог болгох** (бутчих, шатаах зэргээр устгах); **үнсэн товрог болох** (шатаж үнс болох).

ТОВРОГЛОХ товрог болгох, сүйтгэх, бүрэлгэх.

ТОВРУУ бөөрөнхий, товгор, усны цөвүүн адил хийсэн чимэг; *товруутай хазаар.*

ТОВРУУТ товруу бий; *товрууг чимэг;* **товруут хадаас** (хаалга зэрэгт хаддаг товруу бүхий хадаас).

ТОВРУУТАЙ товруу бүхий; *товруутай монгөн тоногтой хазаар худрага.*

ТОВТОЙ шийдвэртэй, шийдтэй; *товтой юм сонссонгүй.*

ТОВХ 1. гутлын өсгий дэх зузаан хэсэг; *өндөр товхтой гутал;* 2. гутлын уланд наалдаж хөлдсөн цас; *гутлын уланд товх наалдах;* 3. тэмээний буйлын үзүүр этгээдийн тогтоох бяцхан шир; *буйлын товх.*

ТОВХГОР тэвхгэр, зузаан; *товхгор дөрвөлжин; товхгор ултай гутал; товхгор хайрцаг.*

ТОВХИМОЛ 1. товхисон юм; *жижиг товхимол дэвтэр;* 2. жижгэвтэр ном; *хүүхдийг хүмүүжүүлэх тухай товхимол хэвлүүлэх гэж бий.*

ТОВХИОС товисон нь; *товхиос сайтай; товхиосгүй.*

ТОВХИУЛАХ товхихын үйлдүүлэх хэв.

ТОВХИХ цаас, бичиг мэтийг давхарлан үдэх, дэвтэр болгох, дэвтэрлэх; *дэвтэр товхих.*

ТОВХОЙЛГОХ товхойхын үйлдүүлэх хэв, товхгор болгох.

ТОВХОЙХ товхгор болох, тэвхгэр болох; *цас товхойтол наалджээ; юм хумаа товхойтол сайхан хураажээ.*

ТОВЧ I шилбийн нүх, тусгай гаргасан нүхэнд оруулж торгох зүйл; *дээлийн товч; ханцуйны товч; товчны шилбэ; товчны сэнж;* **хөхний товч** (хүний хөхний гадна талын бяцхан бөөрөнхий шомбогор); **замагны товч** (замагны барнул бөөрөнхий); **цахилгаан товч** (түлхүүр мэт зүйлийг гүйлгэн халаас, энгэр зэргийг нээх хаах төмөр эдлэл).

ТОВЧ II хураангуй; *товч түүх; товч тайлбар; товч дүгнэлт хийх; товч хэлэхэд...; үгний товч; товч дүн; товчин төдий дурдахад ийм байна.*

ТОВЧДОХ хэтэрхий товч болох.

ТОВЧДУУЛАХ товчдохын үйлдүүлэх хэв.

ТОВЧИХ юмыг тасалдахгүй зүйл зүйлээр маш тодорхой ярих, хэлэх.

ТОВЧЛОГДОХ товчлохын үйлдэгдэх хэв.

ТОВЧЛОЛ утгыг хураангуйлан товчилсон юм; *номын товчлол; заах хичээлийн товчлол.*

ТОВЧЛОХ I товчийг шилбэ буюу нүхэнд нь оруулан торгох; *товч; товчлох; энгэр заамаа товчлох.*

ТОВЧЛОХ II 1. богино бага болгох, хураангуйлах; *жилийн газрыг сараар товчилж, сарын газрыг өдрөөр товчилж...* (үлгэрээс); 2. утгыг хураангуйлах; *товчилж ярих;* **товчлон захирах** (хамтатган захирах).

ТОВЧЛУУЛАХ 1. товчлохын үйлдүүлэх хэв; 2. товчлогдох.

ТОВЧЛУУР амьтны эгэм яс ба өнгөлүүр; *хүний товчлуур; шувууны товчлуур;* **товчлуур төмөр** (үүд хаалгыг хөндлөн торгох төмөр).

ТОВЧОО I бүгд тоо, хураангуй, бүгд тооны хураангуй; *товчоо хийх; хүн амын товчоо; бүртгэлийн товчоо.*

ТОВЧОО II 1. ямар нэгэн зүйлийг эрхлэх албан газар; *тоо бүртгэлийн товчоо;* 2. зарим байгууллагын удирдах хэсэг; *намын үүрийн товчоо;* **улс төрийн товчоо** (ардын хувьсгалт намын төв хорооны тэргүүлэгч гишүүд).

ТОВЧООХ товчлох, товчоолох, хураангуйлах.

ТОВЧРУУТАХ товч мэт болцруутай болох.

ТОВЧРУУТУУЛАХ 1. товчруутахын үйлдүүлэх хэв; 2. товчуурлах.

ТОВЧУУРЛАХ хавтаг мэтийн хуниастай савны амыг утсаар зөрүүлж тойрон боон уях.

ТОВЧХОН баахан хураангуй, нилээд товч; *товчхон илтгэж танилцуулав.*

ТОВШИГДОХ товшихын үйлдэгдэх хэв.

ТОВШИХ I 1. хол хол хатган нэвтэлж оёх; *гутлын ул товших;* 2. шилжсэн хүний зан байдлыг туршиж үзэх; *ямар байдалтай байгаагий нь товшоод үзье.*

ТОВШИХ II хөлөөр нөгөө этгээдийн хажуу талаас цохих бөхийн мэх; *товшиж унагаах.*

ТОВШИХ III товшуур хөгжмөөр тоглох.

ТОВШООС товшиж оёсон оёдол; *товшоос нь холджээ.*

ТОВШУУЛАХ 1. товшихын үйлдүүлэх хэв; 2. товшигдох.

ТОВШУУР товшиж дуугаргах хөгжим; *товшуур хөгжим; товшуурын чавхдас.*

ТОВШУУРДАХ товшуур хөгжмөөр хөгжимдөх.

ТОВШУУРДУУЛАХ товшуурдахын үйлдүүлэх хэв.

ТОВЪЁГ гарчиг, аливаа албан хэргийн товч цэс; *товъёг хийх.*

ТОВЬ: товь малгай 1. дөрвөн тал саравчтай малгай; 2. хуучирсан дуулганы дотуур давхарлан өмсөх малгай.

ТОВЬД тэвш.

ТОГДГОНОХ тогдгор юмны үргэлжлэн хөдлөх.

ТОГДГОНУУЛАХ тогдгонохын үйлдүүлэх хэв.

ТОГДГОР тагдгар, оготор, богинохон; *тогдгор дээл.*

ТОГДГОРХОН баахан тогдгор, арай тогдгор.

ТОГДОЙЛГОХ тогдойхын үйлдүүлэх хэв.

ТОГДОЙХ тогдгор болох; *богинохон дээл өмсч тогдойх.*

ТОГДОЛЗОХ тогдгор юмны байн байн хөдлөх.

ТОГДОЛЗУУЛАХ тогдолзохын үйлдүүлэх хэв.

ТОГИЛ: тогил бургас у р г а м а л намаг, чийгтэй газар бут бутаар ургадаг нэг зүйл бургас.

ТОГЛОГДОХ тоглохын үйлдэгдэх хэв.

ТОГЛОГОР хүч мариа сайтай хүн; *тоглогор эр.*

ТОГЛОЙЛГОХ тоглойхын үйлдүүлэх хэв.

ТОГЛОЙХ хүний булиа махлаг болох.

ТОГЛОМТГОЙ тоглох дуртай.

ТОГЛОМХОЙ тоглох, тоглоом хийх зантай.

ТОГЛООМ 1. тоглоход хэрэглэх зүйл; *хүүхдийн тоглоом; тоглоомын морь; тоглоомын буу;* **тоглоомын талбай** (хүүхэд наадахад зориулан зассан талбар); 2. наадах хэрэгсэл; *улаан буланд шатар, даам зэрэг тоглоом бий;* **мөрийтэй тоглоом** (эд юмаар мөрий тавьж тоглох наадам); 3. доог, даажин; *ахаараа тоглоом хийх нь үү? тоглоом тоотой нь дээр, толгой мөлжүүртэй нь дээр* з ү й р; **тоглоом даах** (даажин, доог хийхэд үл уурлах; *тоглоод тоглоом даахгүй*); ☆ **тоглоомын засгийн газар** (ард түмний олонхийн санал хүсэлээр байгуулагдаагүй бөгөөд хөрөнгөтөн улс гүрний заавар хатгалгаар аливаа зүйлийг гүйцэтгэх засгийн газар).

ТОГЛООМЧ тоглох дуртай хүн.

ТОГЛОХ 1. амьтны сэтгэл хөөрөн баясч зугаагаа гаргах; *голын эрэг дээр хүүхэд өдөржин тоглох; хурга тоглох;* 2. зугаа гаргах, амрах, уралдаан тэмцээн хийхийн тул ямар нэгэн юмаар оролдож цагийг нөхцөөх; *бөмбөг тоглох; нуугдаж тоглох; шатар тоглох; биллиард тоглох; даалуу тоглох;* 3. урлагийн алив нэгэн зохиолыг үзүүлэх, сонсгох; *жүжиг тоглох; кинонд тоглох; гол рольд тоглох; бүжиг тоглох; цирк тоглох; сургуульдай амьтад тоглох; морин хуур хөгжмөөр тоглох; төөлдөр хуураар чадамгай тоглох;* 4. доог, даажин хийх, хуурах; *худал худал, би тоглосон юм; хүн хүнээр тоглох нь байтугай, хүүхэд чулуугаар тоглодоггүй цаг шүү* з ү й р.

ТОГЛУУЛАХ 1. тоглохын үйлдүүлэх хэв; 2. тоглогдох.

ТОГОНЦОГ эмэгтэй хүний охор түрийтэй гутал.

ТОГОО (Н) 1. идээ болгох сав; **тогоо шанага, гал тогоо** х о р ш.; *ширмэн тогоо; халуун тогоо;* **тогоо барих** (хоол унд хийх); ☆ **тогоо нэрэх** (үхрийн айргаар архи нэрэх); **тогооны хүн** х у у ч и р с а н (эхнэр); **гал тогоо, тогооны газар** (хоол унд хийх газар); **нэг тогооноос хоол идэх** (нэгэн газарт хамт байсан); 2. алив **зүйлийг халаах, буцалгах** том сав; **уурын тогоо.**

ТОГООЛОХ 1. галлаж тогоо **тавин** хоол хош хийх; 2. тогоо нэрдэг болох.

ТОГООТОЙ тогоо бүхий, тогоон дахь юм; *тогоотой цай буцлав; тогоотой юм чинь болсон биш үү?*

ТОГООЧ идээ хоол хийхдээ мэрэгжсэн хүн; *ахлах тогооч.*

ТОГОРУУ а м ь т а н өнгө хөхөвтөр, хүзүү хөл урт, сүүл шувтан, хос хосоор явдаг том шувуу; *тогорууны цуваа.*

ТОГОС а м ь т а н бие их, ноолуур ногоон, сүүл урт болоод үзүүртээ таван зүйлийн өнгөт нүдтэй, үзэсгэлэнт шувуу; *тогосын өд.*

ТОГТВОР суурь, тогтоц; **тогтвор суурьшил** х о р ш.: **тогтвор суух** (томоожих, төлөв томоотой болох).

ТОГТВОРГҮЙ 1. суурь, тогтоц муутай; *тогтворгүй ваар; гэр бүлийн талаар тогтворгүй хүн байж болохгүй;* 2. нэг газар удаан байж үл чадах; *тогтворгүй хүн;* 3. ш и л ж с э н сэтгэл нь донсолсон, уймарсан, уймраа; *сэтгэл тогтворгүй болох.*

ТОГТВОРЖИХ тогтвор олох, тогтох, суурьших.

ТОГТВОРЖУУЛАХ тогтворжихын үйлдүүлэх хэв.

ТОГТВОРЛОХ тогтвортой болох, тогтворжих.

ТОГТВОРТОЙ тогтвор бүхий, суурьшилтай, тогтоцтой; *тогтвортой суух; тогтвортой санаа.*

ТОГТВОРШИХ тогтвор олох шинжтэй болох.

ТОГТМОЛ 1. үл хөдлөх, суурьшил, тогтвор, нэгэн газраа орших; *тогтмол ус;* 2. хэвшмэл, нэгэн хэвтээ байх, байнга; *тогтмол заншил.*

тогтмол хэрэг (хэзээд хэвээрээ байх хэрэг); тогтмол үг (заншсан үг).

ТОГТМОЛЖИХ тогтмол болгох.

ТОГТМОЛЖУУЛАХ тогтмолжихын үйлдүүлэх хэв.

ТОГТНИЛ тогтних үйлийн нэр; *тогтнил сайтай; тогтнил муутай; тусгаар тогтнил.*

ТОГТНИЛГҮЙ тогтвор, тогтоц муутай.

ТОГТНИЛТОЙ тогтнил бүхий, тогтнил сайтай.

ТОГТНИУЛАХ тогтнихын үйлдүүлэх хэв.

ТОГТНИХ 1. тогтуун, тайван болох; *олны санаа тогтних;* 2. тур тогтох, тогтзонох; *мал тогтних нь шиг байна;* 3. улс гэр, айл өрх сууршилтай бат тогтох; *тусгаар тогтнисон улс болов.*

ТОГТОНГИ тогтнисон байдал зогсонги; *тогтонги байдал; тогтонги өвчин.*

ТОГТОНГИЖИХ тогтонги байдалтай болох.

ТОГТОНГИЖУУЛАХ тогтонгижихын үйлдүүлэх хэв.

ТОГТОНГИРОХ тогтонги болох.

ТОГТОНГИШИХ тогтонги шинжтэй болох.

ТОГТООГДОХ тогтоохын үйлдэгдэх хэв; *дээрээс тогтоогдсон хэрэг.*

ТОГТООЛ 1. олноороо хэлэлцэж гаргасан шийдвэр буюу засгийн заавар тушаал; **тогтоол заавар** хорш.; *бүх гишүүдийн хурлын тогтоол; Сайд нарын Зөвлөлийн тогтоол;* 2. юмны тогтвол зохих хэмжээндээ хүрэх нь; *тогтоолоо олжээ;* **зүй тогтоол** (жам ёс).

ТОГТООЛГОХ тогтоохын үйлдүүлэх хэв; *орон тоогоор хэдэн хүн байхыг тогтоолгох хэрэгтэй; сургуулийн хүүхдээр шүлэг тогтоолгож байна.*

ТОГТООХ тогтохын үйлдүүлэх хэв, 1. алив юмыг үүсгэх, бий болгох, байгуулах; *Ардын засгийг тогтоох* 2. тогтоол гаргаж батлах; *тэргүүлэгчдийн хурлаас тогтоосон нь...* 3. явуулахгүй, алдахгүй байлгах; *хонио тогтоож хирүүлах; үрүүдсан адууг тогтоов;* 4. цээжлүүлэх; *шүлэг тогтоох; юм тогтоохдоо сайн хүн байгаа юм.*

ТОГТОХ 1. хөдөлбөргүй болох, үл хөдлөх; *оршин тогтох; мал тогтмоор газар;* **ус тогтох** (урсахгүй нэг газраа байх); **нас тогтох** (залуугийн хөнгөмсөг, хийсвэр байдал үгүй болох); **сэтгэл тогтохгүй байх** (энэ тэрийг санан сэтгэл амрахгүй болох); 2. бий болох, үүсч гарах; *ардчилсан засаг тогтох; үүл тогтох; булдруу тогтох; сорви тогтох;* 3. урсч хөдөлж байсан юм урсах, хөдлөхөө болих, зогсох; *бороо тогтох; салхи тогтох; хамраас цус вараад тогтов;* 4. өвчин өдгэрсний дараа биед эмгэг хоцрох; *мэнгэр тогтох; өвчнөөс юм тогтох;* 5. шийдвэрлэх, шийдэх, нэгэн тийш болох; *хэлэлцэн тогтох; тогтсон шийдвэр; намын үүрийн нарийн бичгийн дагаад даалгахаар тогтов.*

ТОГТУУРИГҮЙ суурь тогтвор муутай; *тогтууригүй хүн; тогтууригүй аваш; тогтууригүй ширээ.*

ТОГТУУРЬ тогтвор, суурь; *тогтуурий нь олох.*

ТОГТУУРЬТАЙ тогтуурь бүхий, тогтуурь сайтай.

ТОГТШИРОХ тогтох шинж байр орох.

ТОГШИГДОХ тогшихын үйлдэгдэх хэв.

ТОГШИХ I өчүүхэн өчүүхэн цохих; *харандаагаар тогших; алхаар тогших; хаалга тогших.*

ТОГШИХ II зэрлэг амьтан юмны чимээ, үнэр сэрж зайлж эдох.

ТОГШОО ацат модонд тор хийж шувуу барих хэрэгсэл.

ТОГШООХ 1. тогшихын үйлдүүлэх хэв; 2. турших; *байдлы нь нэг тогшоогоод үзье.*

ТОГШУУЛАХ 1. тогшихын үйлдүүлэх хэв; 2. тогшигдох.

ТОГШУУР 1. манаа манах зэрэгт тогших зэвсэг; 2. малгайт хадаас хацах бяцхан алх; **тогшуур тогших** (тойрон байгсад юм гүйлгэж тогших дуу зогсохоод мөн юм барьж буй этгээд баа хүлээх наадам); 3. тогшуурга.

ТОГШУУРГА 1. тогшуур; 2. амьтан хушуу цүүц мэт, хумс матигар бөгөөд хурц, хошоодоор ой модонд явах ба хорхой шавьж эрэхдээ хушуугаараа мод тогшдог жижигхэн шувуу

ТОГШУУРЧ тогшуур тогших хүн.

ТОД харагдах нь сайн, бүдэг биш, тодорхой, илэрхий, илхэн; **ил тод, тод томруун** х о р ш.; *тод харагдах; тод сонсдох; тод хэлэх; дурангаар харахад тод ялгагдаж байв; тов тод харагдаж байгаа юм;* **тод үсэг** (Ойрдын Зая Бандида гэгч 1648 онд зохиосон нэг зүйл монгол бичиг).

ТОДДОЛ тоддох үйлийн нэр.

ТОДДОХ хэтэрхий тод болох.

ТОДОГ а м ь т а н хээрийн галуунаас том, хүзүү бүдүүн, өвчүүний ноолуур цагаан, арын өрөвлөг эрээн, сүүл охор нэгэн зүйл шувуу; **тодог тогоруу** х о р ш..

ТОДОЛ: хар тодол а м ь т а н өнгө хар, цээж этгээдэд цагаан толбо буй, хушуу урт, хорхой иддэг жижиг шувуу.

ТОДОРХОЙ 1. илт, илэрхий, тод; *тодорхой ухагдахуун; саналаа товч бөгөөд тодорхой хэлэх; утга учир нь тодорхой; тодорхой санагдах;* 2. нэгд нэгэнгүй, дэлгэрэнгүй; *тодорхой ярих; тодорхой мэдэх;* 3. бодитой; *тодорхой арга хэмжээ авах; тодорхой жишээ.*

ТОДОРХОЙДОХ хэтэрхий тодорхой болох.

ТОДОРХОЙЛОГДОХ тодорхойлохын үйлдэгдэх хэв.

ТОДОРХОЙЛОЛ тодорхойлох-үйлийн нэр; *онолын тодорхойлол.*

ТОДОРХОЙЛОЛТ тодорхойлсон нь; *ажлын тодорхойлолт; тодорхойлолтын асуулт.*

ТОДОРХОЙЛОХ 1. илэрхий болгох, тодорхой болгох, илрүүлэх; *хэргийн учрыг лавшруулан тодорхойлж ирүүлнэ үү;* 2. бичих, хэлэх мэтээр учир байдлыг тоочих; *учир шалтгааныг тодорхойлон ирүүлэх хэрэгтэй; тодорхойлж өгөх.*

ТОДОРХОЙЛУУЛАХ тодорхойлохын үйлдүүлэх хэв.

ТОДОТГОГЧ тодотгодог, тодруулдаг юм; **тодотгогч шил** (өсгөдөг шил, томруулах шил).

ТОДОТГОЛ 1. тодотгох үйлийн нэр; 2. хэний, юуны, аль, ямар, яасан гэх зэрэг асуултанд хариулагдах өгүүлбэрийн туслах гишүүн.

ТОДОТГУУЛАГЧ 1. тодотгуулж байгаа юм; 2. тодотгуулж буй үг.

ТОДОТГОХ 1. тод болгох; *балархай газруудыг тодотгох хэрэгтэй;* 2. ш и л ж с э н **ил,** илт болгох, далд биш болгох; *утга санаагий нь тодотгох.*

ТОДОТГУУЛАХ тодотгохын үйлдүүлэх хэв.

ТОДРОХ I. тод болох; *ойртож ирэхдээ тодорч байна;* 2. ш и л ж с э н илт, илэрхий болох, ил гарах; *учир нь тодрох;* 3. х у у ч и р с а н хугарт хувилгаадын хойт дүр гэгч төрж бий болох.

ТОДРУУЛ гэрэл зургийн хальс, шил зэрэгт буусан дүрсийг тодруулан гаргах найрлага бүхий хор.

ТОДРУУЛАГДАХ тодруулахын үйлдэгдэх хэв.

ТОДРУУЛАХ тодрохын үйлдүүлэх хэв, тодорхой болгох.

ТОДТОХ улам тод тодорхой болох.

ТОДХОН тод, баахан тод; *тов тодхон; тэргэн цэнхэр огторгуй минь, тодхон саруул харагдана* (дуу).

ТОЖГОНОХ тожгор юмны үргэлжлэн хөдлөх.

ТОЖГОНУУЛАХ тожгонохын үйлдүүлэх хэв.

ТОЖГОР I үс, ширхэг бага, богино; *тожгор сүүлтэй буурал морь; тожгор шүүр.*

ТОЖГОР II 1. амьтны бие маш хомс жижиг бөгөөд эцэнхий туранхай; *тожгор бяруу; тожгор ишиг; тожгор хүүхэд;* 2. хувцас хунарын бага, татанхай, хуучирч элэгдсэний нь; *тожгор дээл.*

ТОЖИГНОХ 1. тор тор чимээ гарч сонсдох; *авдар доогуур юм тожигноод байна;* 2. зөөлөн хүүрэг биш, хатуу, хатанги байдалтай болох; *тожигносон боорцог болжээ.*

ТОЖИГНУУЛАХ тожигнохын үйлдүүлэх хэв.

ТОЖИЙЛГОХ тожийхын үйлдүүлэх хэв.

ТОЖИЙХ тожгор болох; *үс нь ойчиж гээгнь тожийж орхив; тожайсон сүүлтэй морь.*

ТОЖИЛЗОХ тожгор юмны байн байн хөдлөх.

ТОЖИЛЗУУЛАХ тожилзохын үйлдүүлэх хэв.

ТОЖИН тожгор; *хүүхэд тожин тожин алхалж байна.*

ТОЙ гэрлэхийн хурим; **хурим той** х о р ш..

ТОЙВ тээр, дараа, дараас, төвөг; *тойвтой ажил; биенд тойвтой юм.*

ТОЙВОР алмуур, суга таяг.

ТОЙВТОЙ тойв бүхий, тойв ихтэй.

ТОЙГ I 1. дунд чөмөг, шаант чөмөгний уулзар болох өвдөгний дээр байх бондгор, дүгрэг яс; *тойгны яс; тойг мултрах;* 2. х у у ч и р с а н мөнгөн гүйлгээнд явах, хонины тойгийн чинээ цутгамал мөнгө; *мөнгөн тойг; таван лангийн тойг.*

ТОЙГ II тойго.

ТОЙГДОХ барилдахад гараар ачих нэгэн зүйл мэх.

ТОЙГЛОГДОХ тойглохын үйлдэгдэх хэв.

ТОЙГЛОХ I тойголох.

ТОЙГОЛОХ II малыг тойгноос нь дарж уях.

ТОЙГЛУУЛАХ 1. тойглохын үйлдүүлэх хэв; 2. тойглогдох.

ТОЙГО: тойго-тойго хургаа голсон хонийг аргадан дуудахад хэлэх үг.

ТОЙГОВЧ өвдгөнд өмсөх өмсгөл, өвдөгч.

ТОЙГОЛОХ 1. хургаа голсон хонийг тойго-тойго гэж уянгалан дуулж хүргы нь авахуулах; 2. ш и л ж с э н бүсдыг арга заль хэрэглэж эрхшээлдээ татах.

ТОЙЛОХ I сувилах, асрах; *аав ээжийгээ сайн тойлох хэрэгтэй.*

ТОЙЛОХ II толгойн үсийг хутгаар авах; *үсээ тойлсон хүүхэд.*

ТОЙМ 1. бараг, барагцаа, бүдүүвчилсэн байдал; *бүдүүн тойм нь ийм байна; тоймы нь хэлэх юм бол..* 2. аливаа нэгэн сэдэвт үзэгдэл юмны товчилсон мэдээ; *олон улсын хоорондын байдлын тойм; ном зүйн тойм; тойм лекци.*

ТОЙМГҮЙ 1. эмх замбараагүй, эх захгүй; учир тоймгүй юм хэлэх; 2. ш и л ж с э н маш олон, туйлын олон; *тоймгүй олон хүн байна.*

ТОЙМИЙ татсан мах ногоо зэргийг зуурсан гурилд хучиж жигнэн хийсэн нэгэн зүйл хоол.

ТОЙМЛОХ 1. тоймы нь гаргах; барагцаалах; 2. бараг ойлгох, барагцаалж мэдэх; *тыйм байх л гэж би тоймлож байна; нарийн мэдэхгүй байна, тоймлоод өгч орхиё.*

ТОЙМЛУУЛАХ тоймлохын үйлдүүлэх хэв.

ТОЙМОГ толгойдоо юмгүй, мухар; **тоймог үхэр** (эвэргүй үхэр); **тоймог толгой** (үсийг тойлсон, хуссан толгой; *тоймог толгойтой, тойруулган захтай лам хүн ирэв*).

ТОЙМТОЙ 1. эмхтэй, цэгцтэй; 2. барагцаалах хэмжээтэй, баримжаатай; *тоймтой хэдэн үгийг хэлэх.*

ТОЙМЧ тойм бичигч; *сонины тоймч.*

ТОЙН 1. ламын хүндэтгэл; **тойн хувраг** х о р ш.; 2. тайж язгууртай лам.

ТОЙНОГ түйнэг.

ТОЙРЛОГО тойрсон юм нь.

ТОЙРОГ 1. од гаргийн хөдлөх зам; *дэлхийн тойрог;* 2. хиймэл дагуул, огторгуйн хөлгийн хөдлөн явах зам; *хиймэл дагуулыг тойрог замд оруулах;* 3. төвөөсөө хайш хайшаа тэнцүү зайтай битүү дугуй; 4. орон даяар тусгай зорилгоор байгуулагдсан газар нутгийн зохион байгуулалт; *сонгуулийн тойрог; тойргийн комиссын бүрэлдэхүүн;* **цэргийн тойрог** (цэрэг-захиргааны томоохон хэсэглэл; *цэргийн тойргийн командлагч*).

ТОЙРОМ нуур байгаад хатаж ширгэсэн шаварлаг хөрстэй газар; *бороо орж тойром бүрд ус тогтов.*

ТОЙРОН 1. эргэн хүрээлэн; **эргэн тойрон** х о р ш.; *цэцгийн мандал тойрон бүжиглэж байв;* 2. орчин, хавь; **орчин тойрон** х о р ш.; *орчин тойрон ханиад томуугүй тайван сайхан байна;* 3. туршид; *жил тойрон хотод суув.*

ТОЙРОНХОЙ гахайн нарийн гэдэс.

ТОЙРОХ 1. юмны гадуур эргэх, хүрээлэх; *ширээ тойрох; хот тойрох;* 2. хэрэг явдлаас зайлсхийх; *гэмт хэргээс тойрох;* 3. хүний үүгээр түүгээр хэсч явах; *хэсч тойрохын хэрэг юун?* 4. зам зэргээс муруйж явах; *замын халтиргаанаас тойрч гарах.*

ТОЙРУУ 1. чиг, дөт биш, холуур; *тойруу зам; тойруу нүүдэл; тойруу хэрэг;* 2. гол зүйлээс зайлсхийн ярих; *тойруу яриа.*

ТОЙРУУДАХ хэтэрхий тойруу болох.

ТОЙРУУЛАХ тойрохын үйлдүүлэх хэв; *хүүхдээ ширээ тойруулан хөөв; нүдээрээ тойруулан харж харж гарав; тойруулан хэлэлцэх хэрэгтэй.*

ТОЙРУУЛГА I юмыг тойрон явах газар, зам; *тэрэгний тойруулга зам;* **морин тойруулга** (мориор тойрч уралдах газар).

ТОЙРУУЛГА II гэрийн өвч дэвсгэр; *таван ханатай гэрийн тойруулга.*

ТОЙХОН: тойхон шонхор а м ь т а н шонхрын төрлийн цагаан шувуу, шувуу бялзуухай барьж идэхдээ сурмаг.

ТОЛБО I юманд тогтсон бөрт; *шар толботой бор морь; нүүр дээр нь хар толбо гарчээ; хувцасны тосон толбыг арилгах.*

ТОЛБО II а м ь т а н лаг мэлхийн төрөл, арынхаа хайрс дээр хээтэй, хайрсаар нь юм хийж болдог мэлхий.

ТОЛБОРОХ толбо болох, толбо гарах.

ТОЛБОТОХ толбо тогтох, толбо суух, толботой болох.

ТОЛБОШИХ толбо тогтох шинж орох.

ТОЛГОД олон жижиг овоо; *овоо толгодоор дамжин явав.*

ТОЛГОЙ I 1. нүүр гавал хоёроос бүтсэн, хүн амьтны биеийн эрхтэн: **толгой тархи, малгай толгой** х о р ш.; *толгойн чимэг; толгойн боолт; толгойн өвчин; толгой өвдөх; тэмээн толгой тэвшинд багтдаггүй, тэнтэгэр хатан зарга шүүдэггүй, ямаан толгой ямбанд багтдаггүй, янтгар хатан зарга шүүдэггүй* (үлгэрээс); **толгой дохих** (толгойгоо бага зэрэг урагш хөдөлгөх); **толгой дүнсийх** (толгой өвдөх байдал орох); **толгой дууганих** (толгой эргэж мэнэрэн өвдөх); **толгой эргэх** (а. толгой дүйрч мэнэрэх; б. ухаан самуурах төөрөх; в. зүг чигээ мэдэхгүй болох); **толгой түрүү** (эх зах, ах зах); **толгой түрүүгүй, эх толгойгүй** (эх захгүй, эмх замбараагүй); **толгой холбох** (а. шүлгийн мөрийг адил дуудлагатай авиагаар эхлэх; б. эр эм бололцох: *тоонотой гэрт толгой холбож, тогоотой шөлөнд хушуу холбох*); **толгой үсэг** (гарчгийн үсэг); **толгой даах** (өөрөө биеэ мэдэх болох, биеэрээ хариуцаж чадах); **толгой өргөхгүй** (толгойгоо дээш татахгүй); **толгой эргүүлэх** (толгой эргэхэд хүргүүлэх, үймүүлэн самуурууллах); **толгойгоо даах** (а. өөрийн үйл явдлыг өөрөө биеэ дааж гүйцэтгэх болох; б. өвчтэй хүн өөрөө өндийн босч чадах); **толгойгоо мэдэх** (өөрийн үйл явдлыг өөрөө мэдэж чадах болох); **толгой мэдэх** (өөрөө өөрийгөө мэдэж чадах); **эх толгойгоо алдах** (а. эмх замбараагаа алдах; б. ах захаа алдах; в. эрээ цээрээ алдах); **толгой хоргодох** (түр зуур хоргодох, байрлах; *хүйтэнд толгой хоргодох газар байна уу?*); **цагаан толгой** (аливаа бичгийн бүх үсэг; *Монгол бичгийн цагаан толгой*); 2. тэргүүн, шилдэг; **толгой тэргүүн** х о р ш.; *гэр бүлийн толгой; дээрэмчний толгой; тэдний адууны толгой нь тэр бор морь байгаа юм;* 3. юмны орой буюу дээд үзүүр; *уурганы толгой; өвсний толгой; унины толгой; ханын толгой; ташаан толгой; сүүжний толгой; шүдэнзний толгой;* **уулын толгой** (уулын нөёлох орой); **мод толгой** (соруулгүй муу ганс); **ганцны толгой** (амны тамхи нэрж татах уурхай); **толгой татах** (гуталд зулаг залгах); **толгой залгах** (уурга мэтийн үзүүрт юм нэмж залгах); **хадаасны толгой** (хадаасны тав бүхий этгээд); **эрхний толгой** (эрхний тоолох эхлэлийн чимэг тэмдэг); **хөөрөгний толгой** (хөөрөгний халбаганы бариул этгээдэд байх шүр зэргээр хийсэн тал бөмбөрцөг); 4. хэсэг тасархай тогтсон жижиг буюу товгор газар; *Зайсан толгой; холбоо толгой; хүрэн толгой;* 5. хүн, малыг төлөөлүүлэн хэлэх үг; *ухаантай толгой; мангуу толгой; хашир толгой; малын тоо толгойг нэмэгдүүлэх; хэдэн толгой малтай вэ?;* **толгой дараалах** (толгой тутмыг оролцуулах); **толгой тоолох** (хүн, мал бүгдийг дараалж бүртгэх, юмыг хүн мал тутамд хүргэх); 6. даваан дээр; *явахын толгой дээр хүн ирж болиулав; галт тэрэг хөдлөхийн толгой дээр сууж амжив.*

ТОЛГОЙ II хэсэг, боодол, багц; *толгой цуунбуу; толгой цаас; нэг толгой шүдэнз; толгой лаа; нэг толгой зүү.*

ТОЛГОЙГҮЙ 1. толгойлогч, тэргүүлэгчгүй; 2. эх зах, эмх замбараагүй.

ТОЛГОЙЛОГЧ тэргүүлэгч, ахлагч, удирдагч; *өрхийн толгойлогч.*

ТОЛГОЙЛОХ I 1. үйл ажлыг тэргүүлэх, ахлах; *албан газар толгойлох; айл өрх толгойлох;* 2. толгой гаргах, толгойтой болох; *гутал толгойлох; сонгино толгойлох; хатиг толгойлох.*

ТОЛГОЙЛОХ II эд юмыг толгой болгон хуваах; *бараа таваар толгойлох; мөнгө цаас толгойлох.*

ТОЛГОЙЛУУЛАХ толгойлохын үйлдүүлэх хэв.

ТОЛГОЙТ толгой бий; *салаа толгойт; хар толгойт иргэн; хөх толгойт цэцэг.*

ТОЛГОЙТОЙ толгой бүхий; *толгойтой хадаас; морин толгойтой хуур; төмөр толгойтой ганс; шүрэн толгойт хөөрөг; арван таван толгойтой хана.*

ТОЛИГОНОХ толигор юмны хөдлөх буюу харагдах.

ТОЛИГОНУУЛАХ толигонохын үйлдүүлэх хэв.

ТОЛИГОР үрчгэр арчгар буюу атриа хуниаагүй юм; *толигор даавуу; толигор арьс.*

ТОЛИЙЛГОХ толийхын үйлдүүлэх хэв, толигор болгох.

ТОЛИЙХ жийгэнэх, толигор болох; *цамцаа толийтол индүүджээ.*

ТОЛИЛЗОХ толигор юмны хөдлөх үзэгдэх байдал.

ТОЛИЛЗУУЛАХ толилзохын үйлдүүлэх хэв.

ТОЛИЛОХ 1. биеэ тольдож харах; 2. хүндэтгэвэл зохих хүний анхааран үзэх; *анхааран толилох ажаануу.*

ТОЛИЛУУЛАХ толилохын үйлдүүлэх хэв; *дээд газар толилуулах; даргад толилуулах; байцаан толилуулъя.*

ТОЛИМОН юмны үрчгэр хорчгоргүй, толигор; *толимон сайхан торго.*

ТОЛИО 1. өнгө жавхаа; *толио сайтай; толио муухантай;* 2. толийж харагдах газар; *нурууны толио дагуулж маажаарай.*

ТОЛИРОХ 1. атирсан үрчийсэн эд юмны толигор болох, толийх; 2. өвчтэй буюу дорой хүний бие эдгэрч тэнхрэн сэхэж дээрдэх; *өвчин нь толирч байна.*

ТОЛИУР барагтай, муу дорой, тааруу; *толиур морь; толиур биетэй хүн; толиур эд.*

ТОЛИУРХАН тааруухан, барагтайхан, муухан; *чанараар толиурхан эд; бие нь толиурхан л байна.*

ТОЛИХ атирсан үрчийсэн зэрэг эд юмыг дэлгэж тэнийлгэх, толигор болгох; *арьс толих; шир толих; адсага толих.*

ТОЛНО ургамал модонд ургадаг, өнгө улаан, амт исгэлэн хүчтэй нэгэн зүйл жимсгэнэ.

ТОЛТИ 1. илд хутгын ишид өмсгөсөн төмөрлөгийн зүйл; *хутганы толти;* 2. хүн амьтны зүрхний угийн бүдүүн судас бүхий хэсэг; *зүрхний толти.*

ТОЛХИ ухаан мохдог, мунхаг; *маш толхи хүн шүү.*

ТОЛХИЛЦОХ хүний хоорондоо маргацалдан тэмцэлхийлэх; *уг толхилцох.*

ТОЛХИУЛАХ толхихын үйлдүүлэх хэв, талхиулах.

ТОЛХИЙ 1. хүтга зэргийн ирт юмаар хэрэгцээгүй юм оролдож мохоох; *тонгорог битгий толхиорой;* 2. морь малыг хэрэгцээгүй үйл ажилд зүй бус хэрэглэж болиох; *хүнины морь толхичихаж болохгүй.*

ТОЛЬ I 1. юмны дүрсийг тусган үзэх хэрэгсэл; *толинд нүүрээ харах; нөлөөтэй толь; ханын толь;* 2. хүрэл, зэс зэрэг юмаар хийсэн өнгөлөг хэрэгсэл; ☆ **анжисны толь** (анжисны дарах хавтгай).

ТОЛЬ II хуучирсан байлдаанд бие хамгаалахын тулд цээжин тус ар өвөртөө зүүж халхавч бамбай болгон хэрэглэж байсан төмөрлөг зүйл.

ТОЛЬ III харь хэл бичгийг хөрвүүлэх дохио бичиг ба мөн үгийн утгыг тайлбарласан бичиг судар; *Монгол-орос толь; Орос-монгол толь; таван хэлний толь; тайлбар толь; нэвтэрхий толь.*

ТОЛЬДОГДОХ тольдохын үйлдэгдэх хэв.

ТОЛЬДОХ 1. толинд харах; 2. эрхэмлэвэл зохих хүний ажааран харах; *намайг тольдож хайрла.*

ТОЛЬДУУЛАХ 1. тольдохын үйлдүүлэх хэв; 2. тольдогдох.

ТОЛЬТ толь бий.

ТОЛЬТОЙ I 1. толь бүхий; *тольтой шүүгээ; тольтой хайрцаг;* 2. шилжсэн өнгө жавхаа сайтай; *тольтой царайлаг хүн; тольтой эд; тольтой сайхан морь.*

ТОЛЬТОЙ II толь бичиг бүхий.

ТОМ I бага жижиг гэдэгтэй эсэргүүцэлдсэн үг; 1 юмны нөгөөгөөс ихий нь; *том аж ахуй; том гэр; том үсэг; том гэгчийн хар юм харагдав; том хувин;* 2. насанд хүрэх; *том болох; том хүн.*

ТОМ II гөрөөс явсан жим зам; *бугын том; аргаль угалзын том.*

ТОМБОГОР жижиг овгор цомбогор; *тэр томбогор толгой дээр гараад бараа хараарай.*

ТОМБОЙЛГОХ томбойхын үйлдүүлэх хэв, томбогор болгох.

ТОМБОЙХ томбогор, цомбогор болох.

ТОМДОХ хэтэрхий том болох.

ТОМДУУЛАХ томдохын үйлдүүлэх хэв, хэтэрхий том болгох.

ТОМИЛОГДОХ томилохын үйлдэгдэх хэв; *хөдөө ажилд томилогдох; багшаар томилогдох.*

ТОМИЛОЛ томилох үйлийн нэр, томилолт.

ТОМИЛОЛТ томилсон нь, томилол; *албан томилолт; томилолтын хуудас.*

ТОМИЛОХ үйл ажилд хүнийг нэр зааж гаргах, тохоох; **тохоон томилох** х о р ш.; *хязгаарт томилох; орон нутагт ажиллуулахаар томилох; тушаалаар томилох; томилон одуулах; сайдын тушаалд томилох.*

ТОМИЛУУЛАХ 1. томилохын үйлдүүлэх хэв; 2. томилогдох.

ТОММОЛ томж хийсэн юм; *томмол дээс.*

ТОМОГЛОХ бусдыг дооглон уйтгах.

ТОМОЛЦОХ томохын үйлдэлцэх хэв; *дээс томолцох.*

ТОМОО байдал, төлөв; *томоо орох; томоо суух;* **томоо тасрах** (ядрах, бие сулдайх).

ТОМООГҮЙ 1. учир мэдэх болоогүй; *томоогүй хүүхэд;* 2. дүрсгүй, төлөв зэхий; *баруун айлын хүүхэд яасан томоогүй юм бэ;* 3. сэрэмж болгоомжгүй; *томоогүй; томоогүй загчах; томоогүй аашлах.*

ТОМООЖИХ томоотой болох.

ТОМООЖУУЛАХ томоожихын үйлдүүлэх хэв.

ТОМООЛОХ тойрон байх; *томоолон суух; томоолон зогсож наадах.*

ТОМООРХОХ томоотой зан байр гаргах.

ТОМООТОЙ томоо түвшин зан байдалтай; *томоотой сайн хүүхэд; гүндүүгүй томоотой хүн шүү.*

ТОМОРХОГ ихэрхэг зантай, ихэмсэг.

ТОМОРХОХ ихэрхэг зан байдал гаргах, ихэрхэх.

ТОМОРХУУ ихэрхэг.

ТОМОРХУУЛАХ томорхохын үйлдүүлэх хэв.

ТОМОРЦОГ туйван, хулс модоор амсар этгээдийг бяцхан болгон сэрвээ тавьж, ёроол этгээдийг их хийж загас гөрөөлөх хэрэгсэл, торомтог ч гэнэ.

ТОМОХ I дээс утас мэтийг тамах, эрчлэх.

ТОМОХ II самар зэрэг юмны үр цөмийг цөмөх.

ТОМОХ III юмны урдуур хойгуур хэрэн явах.

ТОМРОХ улмаар том болох.

ТОМРУУЛАХ томрохын үйлдүүлэх хэв.

ТОМРУУН 1. томоохон; 2. ил тодорхой; **томруун тодорхой** х о р ш..

ТОМСГОХ томтгох.

ТОМСОХ I улмаар том болох.

ТОМСОХ II том хүний зан байдал гаргах.

ТОМТГОХ томтохын үйлдүүлэх хэв, улмаар том болгох, томсгох.

ТОМТОХ улмаар том болох.

ТОМУУ халдварт ханиад; **тахал томуу, ханиад томуу** х о р ш.; **томуу хүрэх** (томуугаар өвдөх).

ТОМУУЛАХ томохын үйлдүүлэх хэв.

ТОМУУРАХ 1. жихүүцэнээс болж хамар бөглөрөн, шингэн нус урсах; 2. томуу өвчин тохиох.

ТОМУУРУУЛАХ томуурахын үйлдүүлэх хэв.

ТОМУУТ томуу бий.

ТОМУУТАЙ томуу бүхий; *томуутай газар сэлгүүцэн явж үл болно.*

ТОМУУТАХ тахал томуу хүрэх.

ТОМШГҮЙ маш их буюу олон, тоолшгүй, томьёолшгүй, хэмжээлшгүй, тоймгүй; *хүн ч тоо томшгүй олон байна;* **тоо томшгүй** (маш олон, их; *тоо томшгүй олон мал билчиж байна*).

ТОМЬЕО 1. нэр; **нэр томьёо** х о р ш.; *шинэ нэр томьёо тогтоох; нэр томьёоны толь бичиг;* 2. тэмдэг; **томьёо тэмдэг** х о р ш.; **томьёоны**

ухаан (юмны гоог үл харгалзан, чанар, хэмжигдэхүүнийг томьёогоор илрүүлэн судлах ухаан, алгебр); 3. мэдээ мэдрэл; *мэдээ томьёо барагдах; мэдээ томьёо алдах.*

ТОМЬЁОЛОГДОХ томьёолохын үйлдэгдэх хэв.

ТОМЬЁОЛОЛ томьёолох үйлийн нэр; *тодорхой томьёололтой зүйл.*

ТОМЬЁОЛОХ 1. юманд нэр томьёо өгөх ба томьёотой болгох; **томьёолсон тэмдэг** (юмыг тогтсон томьёогоор тэмдэглэсэн тэмдэг); 2 тойм, багцаа; *ачаа бараагаа томьёолж үзье.*

ТОМЬЁОЛУУЛАХ 1. томьёолохын үйлдүүлэх хэв; 2. томьёологдох.

ТОМЬЁОЛШГҮЙ хэмжээлшгүй, томьёолох аргагүй.

ТОН I хүч нэмэгдүүлэх үг: маш, онц, хэтэрхий; *тон их; тон бага; тон сайн; тон тодорхой; тон тусгүй; тон базаахгүй; тон аятайхан; тон ялихгүй дутаж байна; тон зүгээр сууж чаддаггүй хүн; тон харамч; тон болдоггүй зантай морь; тон сүрхий зуудаг нохой; тон хялбар; тон хэцүү; тон амаргүй.*

ТОН II: **тон тон хийх** юмны дэлдэгдсэнээс цууриа багатай гарах чимээ; *мод тон тон хийж байна; тон тон тонших-толгой өвдөх, тон зүгээр суух-гэдэс өлсөх* (тоншуул шувууны үг).

ТОНГОГОНОХ юмны тонгого тонгого хөдлөх.

ТОНГОГОНУУЛАХ тонгогонохын үйлдүүлэх хэв.

ТОНГОЙЛГОХ тонгойхын үйлдүүлэх хэв.

ТОНГОЙХ 1. хүний нуруу бөхийж бөгс хойш болох; *тонгойн сууж байв;* 2. **мал** гөрөөс зэрэг амьтны хүзүү толгойгоо доош болгох; *морь тонгойж ус уув;* **нар тонгойх** (нар хэлбийх).

ТОНГОЛЗОХ юмны тонгос тонгос хөдлөх.

ТОНГОЛЗУУЛАХ тонголзохын үйлдүүлэх хэв.

ТОНГОРОГ эвхмэл жижиг хутга; *энэ чинь яасан хурц тонгорог вэ.*

ТОНГОРОГДОХ тонгорохын үйлдэгдэх хэв.

ТОНГОРОХ 1. морь малын хойт хоёр хөлөө дээш дэгдээж муухай аашлах; *морь тонгорох; азрага тонгорч байв;* 2. толгой доош, хөл дээш босч хэт улбирах, хөрвөх, онхолдох; *орон дээрээс тонгорон унав;* 3. бөхийн мэх, цээжин бие хүчлэн татаж давуулан савж унагаах; *ташаалдаж тонгорох; гар дээрээ сунгаж тонгорох;* 4. аяга сав мэт юмны амыг доош хандуулж, ёроолыг өөд болгох, хөнтрөх; *том хултай айргийг нэг амьсгалаар тонгорч орхиод гарав.*

ТОНГОРУУЛАХ 1. тонгорохын үйлдүүлэх хэв; 2. тонгорогдох.

ТОНГОРЦОГЛОХ 1. хүний толгой доош, хөл дээш, хэт улбирах; *хүүхэд тонгорцоглон наадаж байв; тонгойж тонгойж тонгорцоглон унаж билээ.* 2. морь малын хойт хоёр хөлөө дээш дэгдээж тонгорох, онхолдох; *би унаж явсан моритойгоо тонгорцоглон ойчив.*

ТОНГОРЦОГЛУУЛАХ тонгорцоглохын үйлдүүлэх хэв.

ТОНЖ онц, гарамгай, тасархай; *тонж тодорхой; тонж тасархай; тонж бөх.*

ТОНЖРОХ 1. ганцаараа шалгаран гарах; *түмний дотроос тонжрон гарсан;* 2. шалгарч мэдэгдэх; *өвчин нь саянаас тонжирч байна.*

ТОНЖРУУЛАХ тонжрохын үйлдүүлэх хэв, шалгаруулах.

ТОНИЛГОХ 1. тонилохын үйлдүүлэх хэв; 2. юмыг огт үгүй болгох, арилгах.

ТОНИЛОЛ тонилох үйлийн нэр.

ТОНИЛОХ 1. амьтны үхэж буюу оргож, тэнэж, завхран зайлж үгүй болох; 2. амьтны муу үйл явдлаас алдрах, гэтлэх; *өвчнөөс тонилох; ялнаас тонилох;* 3. хүний үхэх; 4. юмны завхаж үгүй болох, арилах.

ТОНИЛУУЛАХ тонилохын үйлдүүлэх хэв.

ТОНИЛШГҮЙ тонилж, үгүй болохын аргагүй.

ТОННА хүндийн хэмжээ, нэг мянган килограмм; *гурван тоннын машин; хоёр тоннын даацтай.*

ТОНОГ 1. юмыг янзлан гоёх чимэглэл; *эмээлийн тоног; дээлийн тоног; хазаарын тоног;* 2. юмны элдэв хэрэглэл; **тоног хэрэгсэл** хорш.; *тэрэгний тоног.*

ТОНОГДОХ тонохын үйлдэгдэх хэв, мөлжигдөх, завшигдах.

ТОНОГЛОГДОХ тоноглохын үйлдэгдэх хэв.

ТОНОГЛОЛ тоноглох үйлийн нэр; **тоноглол төхөөрөмж** х о р ш.; *тоноглол сайтай; тоноглол муутай; үйлдвэрийн тоноглол.*

ТОНОГЛОХ 1. юманд чимэг тоног хийх; *дээл тоноглох; эмээл тоноглох;* 2. юмыг тоног хэрэглэлтэй болгох; *үйлдвэрийг тоноглох.*

ТОНОГЛУУЛАХ 1. тоноглохын үйлдүүлэх хэв; 2. тоноглогдох.

ТОНОГЧ бусдыг тонодог, мөлжигч, тонооч, тонуулч.

ТОНОДОС юмнаас тонож авсан зүйл.

ТОНООЧ тоногч, тонуулч.

ТОНОХ бусдын юмыг арга хүч хэрэглэж мөлжин ашиглах; *тонох дээрэмдэх; тонох мөлжих.*

ТОНТГОНОХ тонтгор юмны үргэлжлэн хөдлөх.

ТОНТГОР бөөрөнхий цомбогор байдалтай юм; *тонтгор аргал; тонтгор гүзээтэй сүү; тонтгор бөгс.*

ТОНТОЙХ тонтгор бүлох; *бөгс нь тонтойх.*

ТОНТОЛЗОХ тонтгор юмны байн байн хөдлөх.

ТОНТУУЛ тоншуул.

ТОНУУЛ 1. тонох үйлийн нэр; *дээрэм тонуул хийх;* 2. тоносон юм; *тонуул эд.*

ТОНУУЛАХ 1. тонохын үйлдүүлэх хэв; 2. тоногдох.

ТОНУУЛЧ (ИН) тонодог мөлждөг этгээд; *тонуулч хүн.*

ТОНХОЛ: энхэл тонхол тэгш, аятай биш; *энхэл тонхол газар.*

ТОНХУУ у р г а м а л иш моголцог болоод хөндий, навч хушуутай, цэцэг шар нэг зүйл ургамал.

ТОНШИГДОХ тоншихын үйлдэгдэх хэв.

ТОНШИЛХИЙЛЭХ байн байн тонших.

ТОНШИХ ихээхэн юмыг бяцхан юмаар тогших; *алхаар тонших; хуруугаар тонших; толгой руу нь тонших; шаазгай тонших;* **хэрээ тонших махгүй** (маш туранхай);

ТОНШУУЛ а м ь т а н тогшуурга шувуу; *ногоон тоншуул; хар тоншуул.*

ТОНШУУЛАХ 1. тоншихын үйлдүүлэх хэв; 2. тоншигдох.

ТОНШУУР тонших хэрэгсэл.

ТОО аливаа үзэгдэл юмыг тоолсны үндсэн дээр хэд хичнээн болохыг тогтоосон хэмжээний илрэл; *торгон дээлтэй боловч тоо мэдэхгүй мунхаг з ү й р;* **бутархай тоо** (нэгэн бүхэл юмны хэсэг); **өрөөсгөл тоо, сондгой тоо** (тэгш тоонд хуваагдахгүй тоо); **хяналтын тоо** (тогтоосон тоо); **тоо авах** (а. тоолох; б. тоолсон мэдээ дүн авах); **тооноос хасах** (бүртгэлээс хасах); **тооноос гарах** (а. бүртгэлээс хасах; б. доройтох, муудах); **тоонд оруулах** (а. бүртгэлд авах; б. сэхэх, дээшлэх; *энэ муу төлөг чинь малын тоонд орох нь байна шүү*); **тоо тоолох** (а. хэд болохыг тоолох; б. тоо унших); **тоо бүрэн толгой мэнд** (тоотой юм, хорогдолгүй хэвээрээ); **тоо бодлого** (тооны ухааны үндсэн хэсэг, тооны хамгийн энгийн чанар, түүнийг бодох аргын тухай үзнэ); **тооны хүрд** (үржүүлэхийн хүрд); **тооны ухаан** (алив юмны хэмжээ, хэлбэр судлах тоо бодлого, томьёоны ухаан, хэмжихүй ухаан, гурвалжны ухаан зэргийн ерөнхий нэр); **тооны машин** (дөрвөн үйлдлээр бодож чаддаг машин); **тоо бүртгэл** (бүртгэл, тооцоо, тооллого; *малын тоо бүртгэл; хүн амын тоо бүртгэл*); **тоо бүртгэлийн судлал** (нийгмийн хөгжил, ардын аж ахуй дахь тооны хувиарлалтыг судлах ухаан); **тоо бүртгэгч** (тоо бүртгэл эрхэлсэн хүн; *бригадын тоо бүртгэгч*); **олон тоо** (юмны олныг заах үг, дагавар; *олон тоо заах дагавар);* **тооны үг** (юмны олон цөөн, дэс дараа, тоололд холбогдол бүхий үгс); **хам тооны үг** (хамт явах, байх, үйлдэх зэрэг байдлыг үзүүлж «хэдүүл» гэсэн асуултад хариулагдах үг); **тоо алдах** (а. тоо ташаарч бодох; б. тоолж барахааргүй их); **тоо томшгүй** (хязгааргүй буюу маш олон); **орон тоо** (алба хаах ор; *орон тооны биш зааварлагч; орон тоо хасах).*

ТООГДОХ тоохын үйлдэгдэх хэв.

ТООГҮЙ I тоолж болшгүй буюу маш олон юм; *тоогүй олон.*

ТООГҮЙ II ай хайран гэж харамсах, өрөвдөх аялга; *хөөрхий, тоогүй дээ!*

ТООДГОР тогдгор, богино, оодон; *тоодгор дээл; тоодгор хормой.*

ТООДОГ а м ь т а н тогорууны язгуурын шувуу, **бие** том, нисэхдээ хүнд нүсэр, нуруу этгээд улаавтар, бор мөн хар эрээвтэр ч бий, **хэвэл этгээд цагаавтар, эрийн хоолойн хажууд**

үнсний өнгөтэй хэсэг өд бий, их төлөв ургамал иднэ, гүйхдээ хурдан; *тоодог муухай, тогоруу сайхан, цамаа харай-цамаа харай* (ардын яриа).

ТООДОЙЛГОХ тоодойхын үйлдүүлэх хэв, тоодгор болгох.

ТООДОЙХ тоодгор болох, тогдойх.

ТООДОН тоодгор, тогдгор, тагдгар; *тоодон сүүл; тоодон дээл.*

ТООЛГОХ 1. тоохын үйлдүүлэх хэв; 2. тоогдох.

ТООЛЛОГО тоолох үйлийн нэр; *тооллого явуулах; эд хогшлын тооллого хийх;* **бүртгэл тооллого** х о р ш.; **тооллогын комисс** (тооллогын ажил гүйцэтгэх үүрэг авсан комисс); **тооллогын төв** (тоо бүртгэл явуулах төв).

ТООЛОГДОХ тоолохын үйлдэгдэх хэв, тоонд оролцох.

ТООЛОЛ он тоолох ёс; *аргын улирлын он тоолол; билгийн улирлын он тоолол; манай тооллын хэдэн онд билээ.*

ТООЛОЛЦОХ тоолохын үйлдэлцэх хэв; тоолоход оролцох; *тоо тоололцох.*

ТООЛОХ 1. юмны чухам хэд хичнээн болохын тоог авах; *тоо тоолох; мал тоолох; тоолж барагдахгүй юм;* 2. тооцох, бүртгэх, оролцуулах; *чамайг сайн хүн гэж тоолоход бэрх; таныхыг зөв гэж тоолох хэрэгтэй; сургуульдаа тоолох.*

ТООЛУУЛАХ 1. тоолохын үйлдүүлэх хэв, тоолоход хүргүүлэх; 2. тоологдох.

ТООЛУУР тоо бодох юм; *тоолуур эрх; тоолуур машин* (тооны машин); **цахилгаан тоолуур** (зарцуулсан цахилгаан хүчийг тоолох хэрэгсэл).

ТООЛШГҮЙ I 1. тоолж баршгүй буюу тоолж болшгүй юм; 2. олон буюу их хэмжээтэй, хэмжээлшгүй юм.

ТООЛШГҮЙ II жаран орондой тооны нэр.

ТООМЖ тоомсор, тоох, анхаарах байдал; *тоомж муутай; тоомж сайтай.*

ТООМЖГҮЙ хайхрамжгүй, **тоомсоргүй**.

ТООМСОГ сайн угсааны эрлийз адуу.

ТООМСОР тоомж, анхаарамж; *тоомсор муутай хүн.*

ТООМСОРГҮЙ юмыг тоож тоомсорлон үзэхгүй; *тоомсоргүйгээс торж унах.*

ТООМСОРЛОГДОХ тоомсорлохын үйлдэгдэх хэв.

ТООМСОРЛОХ юмыг анзаарч хайхран үзэх; *юмыг тоомсорлож явах хэрэгтэй.*

ТООМСОРЛУУЛАХ 1. тоомсорлохын үйлдүүлэх хэв; 2. тоомсорлогдох.

ТООМШИР тоомсор, тоомж.

ТООМШИРГҮЙ тоомсоргүй, тоомжгүй.

ТООНО I монгол гэрийн унь тогтоож байдаг, цамхагтай дугуй цагариг; *таван ханатай гэрийн тооно; арван ханатын тооно.*

ТООНО II: **тооно туших** 1. нэгэн зүйл уяа; *тооно тушиж уяхгүй бол сүүлдээ тайлахад бэрхтэй шүү;* 2. мөн уяагаар уях.

ТООНОЛЖИН хөндлөн гулд чагталсан зураг тэмдэг; *тооноложин тэмдэг тавь!*

ТООНОЛЖЛОХ юмыг баллах дарах зэрэгт дээрээс нь тооножлох хийх.

ТООНОТ тооно бий.

ТООНОТОЙ тооно бүхий; **тоонотой гэрт толгой холбож суух** (эр эм бололцох).

ТООНОЧ тооно хийх мэрэгжилтэй хүн.

ТООНЦОГ тогонцог.

ТООР у р г а м а л улаан шар өнгөтэй, үсэр хэг арьстай, сайхан амттай нэг зүйл жимс, мөнхүү жимс ургасан мод; *тоорын мод;* **тоор цэцэг** у р г а м а л (өнгө цагаан, сүлжсэн мэт цэцэг); **тоор мод** (уянгат мод).

ТООР II: **тоор урхи** шувуу барихад зориулж хийсэн хялгасан урхи.

ТООРИНХОЙ тойронхой.

ТООРМОС машин, галт тэрэг зэрэг юмны хөдөлгөөнийг удаашруулах буюу зогсоох хэрэгсэл.

ТООРМОСЛОГДОХ тоормослохын үйлдэгдэх хэв.

ТООРМОСЛОХ тоормосоор зогсоох.

ТООРМОСЛУУЛАХ 1. тоормослохын үйлдүүлэх хэв; 2. тоормослогдох.

ТООРОГ шингэн юманд хийх шингэн биш хольц.

ТООРОГТОЙ тоорог бүхий; *тооргогтой ус.*

ТООРОЙ I у р г а м а л удын намын нэг зүйл мод, дотроо олон зүйл; **тоорой цэцэг** у р г а м а л (жүрүржийн цэцэгтэй адил болоод навч бяцхан, зун цэцэглэдэг нэгэн зүйл цэцэг).

ТООРОЙ II хурга ишгэнд тэжээл өгөхөд өс хэрэгсэх бол үглэн дуудах үг.

ТООРОЙЛОХ тоорой тоорой гэж өндөр дуугаар аялгуулах; *хурга тооройлох*

ТООРОМ лууван.

ТООРЦОГ I цэцгийн цоморлог; **тоорцог хэнгэрэг** (хөгжмийн зэвсэг).

ТООРЦОГ II бөмбөгөр хэлбэртэй нэгэн зүйл малгай.

ТООС (ОН) нарийн хумхи; **тоос шороо** х о р ш.; *өлөн тоос; нарийн тоос;* **тоос болох** (юман дээр тоос суух); **тоос гарах** (тоос бий болох); **тоос хадах** (тоос дээш ихэд бужигнан **хөдлөх**); **тоос манарах** (тоос дэгдэн бужигнах); **тоос татах** (тоос манаран түгэх); **тоос бургих** (тоос бужигнаж хөөрөх); **хумхийн тоос** (гэрэл туяанд харагдах төдийн нарийн хумхи); **тоосон товрог** (юмны хуу арилж үгүй болохы нь); **тоосон товрог болох** (юм тоос мэт болон сарниж үрэгдэх).

ТООСГО (Н) туйпуу, зөн ч гэнэ.

ТООСГОРОХ тоосго мэт болох.

ТООСЛОХ юмны тоосыг арилгах.

ТООСЛУУЛАХ тоослохын үйлдүүлэх хэв.

ТООСОРХОГ тоос ихтэй, тоос мэт.

ТООСОРХУУ 1. тоосорхог; 2. тоос мэт.

ТООСРОХ салхинд тоос дэгдэх ба манан **хүдэн** болох.

ТООСРУУЛАХ тоосрохын үйлдүүлэх хэв.

ТООТ тоо бий; *арван тоот хашаа; гурван тоот бичиг; таны... тоотыг үзэж танилцав; есөн тоот байшин.*

ТООТОЙ I. тоолсон юм, юмны маш их буюу олон; *тоотой юм гэсэндээ гарын ая их дааж байна;* 2. юмны цөөн буюу бага; *тоотой юм болохоор тон ч амархан барагдаж байна; энэ хэргийг тоотой хүн мэднэ байх аа; тоотой хоногийн үйлэнд тоогүй муухай даслаа шүү* (ардын дуу).

ТООТОЙХОН нилээд тоотой, баахан тоотой.

ТООТОН зарим нутаг ус хийх том хавчиг савын нэр.

ТООХ 1. хүний бусдын хийсэн үйл явдлыг санаандаа зохицсонд үзэж тоомсорлох; *та хэнийг тоох юм бэ?* 2. хүний биеэ сайн сайханд буюу чадвартайд үзэж гайхуулах; *биеэ тоох.*

ТООХГҮЙ юмыг үл тоомсорлон байх, ажрахгүй, анхаарахгүй; *хүн тоохгүй байхад тоолгох гэхийн хэрэг алга.*

ТООЦОГДОХ тооцохын үйлдэгдэх хэв; *энэ хууль батлагдсан өдрөөс эхлэн хүчинтэйд тооцогдоно.*

ТООЦОО юмыг тооцож гүйцэтгэх үйлийн нэр; *тооцоогоор тавьж олгох; тооцоо хийх; тооцоо гаргах; аж ахуйн тооцоотой газар; тооцооны нябо; тооцооны дэвтэр; тооцоогоо дуусгах.*

ТООЦООЛОХ тооцоо хийх, тооцоо бодох.

ТООЦОХ I. юмны данс тооцоог бодож дуусгах; *ажлаас халагдагсадтай сайн тооцох хэрэгтэй;* 2. юмыг бүртгэл тоонд оруулах; *бүртгэл тооцоонд бүртгэн тооцохгүй зүйл байж үл болно;* 3. тоолох, бодох; *түүнийг сайн хүн гэж тооцож болохгүй; хурал нээхэд хүчинтэйд тооцож хурлаа нээе.*

ТООЦУУЛАХ тооцохын үйлдүүлэх хэв.

ТООЧИГДОХ тоочихын үйлдэгдэх хэв.

ТООЧИЛЦОХ тоочихын үйлдэлцэх хэв; *та хоёр нэгнийхээ мууг тоочилцоод яах нь вэ.*

ТООЧИХ учир явдлаа бүрнээ илчлэн хэлэх; *хэрэг явдлаа тоочих; санаа зорилгоо тоочих; жаргал зовлонгоо тоочих.*

ТООЧУУЛАХ 1. тоочихын үйлдүүлэх хэв; 2. тоочигдох.

ТОПОГРАФИ газрын гадаргын хэлбэр хэмжээг зураг буулгах байр зүй.

ТОПОГРАФИЧ топографийн мэргэжилтэй хүн.

ТОР I дэгдсэн тоос.

ТОР (ОН) II сийрэг саргар нэхээстэй юм; *тор нэхэх; загасны тор; орны тор; цонхны тор; торон саа.*

ТОРГО (Н) ёнхор мяндсаар нягт нэхсэн хээнцэр эд; **торго торгомсог** хорш.; *хуурамч торго; бүтэн артай торго; дутуу артай торго; торгон угас; торгон дээл;* **торгон гал, торгон дөл** (галын дөл); **торгон элс** (маш нарийн ширхэгт элс); **торгон цэрэг** (бие хамгаалах шадар цэрэг); **торгон савхи** (маш гялгар болгож өнгөлсөн нимгэн нарийн савхи); **торгон илэг** (маш зөөлөн элдүүр бүхий нарийн илэг, хамба илэг ч гэдэг); **торгоны хорхой** (хүр хорхой).

ТОРГОГДОХ торгохын үйлдэгдэх хэв.

ТОРГОГЛОХ 1. шахамдаж, дэмий марган хэлэлцэх; 2. ажил үйлдвэр хийхгүй дэмий сэлгүүцэн явах; 3. урагдсан хувцсыг бүдүүвчлэн оёх.

ТОРГОЛЗОХ үйл явдалд арайхан автагдах дийлдэхгүй дөнгөж аргацаан тогтоож байх; *хялгасан дээр торголзох; дээсэн дөрвөн дээр торголзох.*

ТОРГОЛЗУУЛАХ торголзохын үйлдүүлэх хэв.

ТОРГОМСОГ 1. ёнхор мяндсаар торгоноос бүдүүвтэр нэхсэн эд бараа; *торгомсог бараа; торгомсог эд;* 2. торго, торгомсог зүйл эдлэхэд дур хүсэлтэй, торгосог ч гэдэг; *торгомсог хүн.*

ТОРГОР *хол* газарт бүртэлзэн харагдах бяцхан бараа; *алст нэг торгор бараан юм харагдана.*

ТОРГОСОГ торгоны зүйл эдлэх дуртай, торго эдлэмтгий, торгомсог.

ТОРГОХ I гэм буруутай явдал үйлдсэн хүнд ял болгож эд мөнгө авах; *ял торгох; мөнгөөр торгох; малаар торгох.*

ТОРГОХ II юмыг тогтнон тороход хүрэх; *оёж торгох; уяж торгох; тулж торгох; утсаар торгох.*

ТОРГУУД баруун монголын нэг ястан.

ТОРГУУЛАХ 1. торгохын үйлдүүлэх хэв; 2. торгогдох.

ТОРГУУЛИГҮЙ 1. торгосон юмгүй; 2. эс торгуулсныг нь; *энэ удаа ч торгуулигүй өнгөрөв.*

ТОРГУУЛЬ I ял болгож авах мөнгө юм; *торгуулийн мөнгө; тавин төгрөгийн торгууль ногдов.*

ТОРГУУЛЬ II юмыг тогтоох уях зэрэгт зориулж хийсэн горхи оньс мэт юм.

ТОРДОГДОХ тордохын үйлдэгдэх хэв.

ТОРДОХ хүн амьтан ба юмыг тэжээх тэтгэх, засч дээшлүүлэх, өөд татах, арчлах, асрах; *биеэ тордох; эцэг эхийгээ тордох; өнчин ядуусыг тордох.*

ТОРДУУЛАХ 1. тордохын үйлдүүлэх хэв; 2. тордогдох.

ТОРЛОГ 1. ургамал тац модны адил болоод өнгө улаавтархан нэгэн зүйл мод; 2. хүнийг жанчих саваа.

ТОРЛОГДОГДОХ торлогдохын үйлдэгдэх хэв.

ТОРЛОГДОХ I торлогоор жанчих.

ТОРЛОГДОХ II торлохын үйлдэгдэх хэв, торонд орох.

ТОРЛОГДУУЛАХ 1. торлогдохын үйлдүүлэх хэв; 2. торлогдогдох.

ТОРЛОХ юмыг тороор хэрэх, холбох; *утсаар торлох; үдээрээр торлох.*

ТОРЛУУЛАХ торлохын үйлдүүлэх хэв.

ТОРМОГОНОХ тормогор юмны үргэлжлэн хөдлөх; *хоёр нүд нь тормогонон харагдав.*

ТОРМОГОНУУЛАХ тормогонохын үйлдүүлэх хэв.

ТОРМОГОР нүдний харц хурц үзэмжтэй; *тормогор нүдтэй охин.*

ТОРМОЗ тоормос.

ТОРМОЗЛОГДОХ тоормослогдох.

ТОРМОЗЛОХ тоормослох.

ТОРМОЗЛУУЛАХ тоормослуулах.

ТОРМОЙЛГОХ тормойхын үйлдүүлэх хэв.

ТОРМОЙХ тормогор болох; *тормойсон хар нүдтэй амьтан.*

ТОРМОЛЗОХ торомгор юмны байн байн хөдлөх; *хөөр нүдээ тормолзуулан инээмсэглэв.*

ТОРМОЛЗУУЛАХ тормолзохын үйлдүүлэх хэв.

ТОРНИУЛАХ горнихын үйлдүүлэх хэв.

ТОРНИУН юмны томхон: *торниун биетэй хүүхэд; торниун хурга.*

ТОРНИХ амьтны багаасаа баахан бойжих; *хүүхэд торниж байна; ишиг торних.*

ТОРОВ хуучирсан бурханд өргөх идээ; *торов тавих.*

ТОРОЙ гахай ба сарлагийн тугал; *торой хариулах; торойгоо дагуулсан мэгж.*

ТОРОЙЛГОХ торойхын үйлдүүлэх хэв.

ТОРОЙХ 1. алсад энд тэнд юмны бараа харагдах; 2. олны дотроос гоцлон гарах, харагдах.

ТОРОМ I хоёр настай тэмээ.

ТОРОМ II ургамал нэгэн зүйл идэшний ногоо, үндэс нь эхүүн үнэр амттай, үндсийг иднэ.

ТОРОМ III сумны онины этгээдийн туусны үзүүрт сүлжин наасан ёнхор утас; *тором орхих.*

ТОРОМГОНОХ тормогнох.

ТОРОМГОНУУЛАХ торомгонохын үйлдүүлэх хэв, тормогонуулах.

ТОРОМГОР тормогор.

ТОРОМЖ мод зэрэгт оосор торгохоор гаргасан хэрчлээс.

ТОРОМЖЛОХ мод зэрэгт хэрчлээс торомж гаргах.

ТОРОМТОГ тариа өвс зэргийг идэхээс болгоомжилж малын аманд углаж өмсгөх тор.

ТОРОМТОГЛОХ малын хушуунд торомтог хийх.

ТОРОХ тулгарах, тээглэх, саатах орох; **хоолой торох** (юм залгихад хоолойд тээглэж, тулгарч байгаа мэт өвдөх); **хавханд торох** (хавханд орох); **торж унах** (тээглэж унах); **торж зогсох** (саатаж зогсох); **ял торох** (ял хэрэгт өртөх, торгогдох).

ТОРОХГҮЙ торох саатах зүйлгүй; *шүлэг торохгүй унших; торохгүй гүйх; торохгүй ярих.*

ТОРТОГ 1. юманд тогтсон утаа; **утаа тортог** хорш.; *тортог болох; тортог суух;* 2. модны давирхай; *тортогтой мод.*

ТОРТОГДОГДОХ тортогдохын үйлдүүлэх хэв.

ТОРТОГДОХ юманд утаа тортог суулгах, тортог болгох; *цаас тортогдох; мах тортогдох.*

ТОРТОГДУУЛАХ 1. тортогдохын үйлдүүлэх хэв; 2. тортогдогдох.

ТОРТОГЖИХ тортогтой болох.

ТОРТОГЛОХ юманд тортог суулгах, тортогтой болгох.

ТОРТОГЛУУЛАХ 1. тортоглохын үйлдүүлэх хэв; 2. тортоглогдох.

ТОРТОГТ тортог бий.

ТОРТОГТОЙ тортог бүхий; *тортогтой мод; нарс мод тортог ихтэй.*

ТОРТОГТОХ юманд тортог суух, тогтох.

ТОРТОГШИХ тортог болох шинж орох.

ТОРУУ нэг ойгоос өнгөрч яваа гахай.

ТОРОХ шингэн юм агуулах сав, хавчиг; торхтой *ус; усны торх; айргийн торх.*

ТОРЧИГНОХ юмны тор тор чимээ гарах.

ТОРЧИГНУУЛАХ торчигнохын үйлдүүлэх хэв.

ТОС (ОН) амьтан, ургамал, чулуулагт байх усанд үл уусах нүнжигт бодис; *хонины тос; сарлагийн тос; өвхний тос; самрын тос; загасны тос; торго өмсөвч сүүдэр нь хар, тос уувч баас нь өмхий* зүйр; **цөцгийн тос** (сүүний цөцгийнөөс ялгаж авсан тос); **цагаан тос** (малын сүүнээс шар тосы нь ялгаж аваад үлсэн идээний хувь); **түүхий тос** (малын сүүнээс авч хураасан өрөм); **шар тос** (малын сүүнээс авсан өрөмний хувийг хайлуулж авсан тос); **олсны тос** (олсны ургамлын үрийн тос); **дэлийн тос** (дэл гэдэг ургамлын үрийн тос); **маалинганы тос** (маалинга ургамлын үрийн тос); **үрийн тос** (самар, шид мэтээс авсан тос); **сүү тосны завод** (сүү авч тос боловсруулах үйлдвэр); **машины тос** (машин техникт хийх тусгай тос); **нүүрний тос** (нүүрний арьсыг гоёмсог байлгахад зориулсан тос); **тосон будаг** (тостой хоршсон будаг; *тосон будгийн зураг*); **тосон туулга** (туулгахад хэрэглэх тосон эм); **тос даах** (тосорхог; *тос даасан бор царайтай*); **тосон өнгө** (сэтгэл дурнаа зохистой аятайхан өнгө); **тосон харгана** ургамал (дурсны өнгө цагаавтар, мах судал нарийн нягт нэгэн зүйл харгана, сумны зэвний иш, тэшүүр сумны бонхгор хийнэ); **тосон харгай** ургамал (цөгүүрсний нам, хөнгөн бөгөөд бат, шилмүүс цөгүүрсний адил болоод өргөн урт, цэцэг маш сайхан нэг зүйл мод, бас шар харгай ч гэнэ).

ТОСВОР тосдог юм.

ТОСГОН жижиг суурин газар; **хот тосгон, гацаа тосгон** х о р ш.; *тосгоны дарга; тосгоны айл; тосгоны охин.*

ТОСГУУЛ тоссон юм.

ТОСГУУР I 1. тоссон юм; 2. ингийн доод чулуу.

ТОСГУУР II 1. юмыг тосгож тавих тавиур; *цайны тосгуур;* 2. юүлүүр.

ТОСГҮЙ 1. нүнжиггүй, нүнжгийн хувь үгүй, заваан; 2. аятай биш, зэвхийдүү өнгөтэй юм.

ТОСДОХ тос түрхэж халдаах; **хушуу тосдох** (тостой юмнаас амсахын төдий болох).

ТОСЛОГДОХ тослохын үйлдэгдэх хэв.

ТОСЛОГ тосорхог юм; *сарлагийн сүү тослог ихтэй;* **сүүний тослог** (сүүнд байх тосны хувь).

ТОСЛОХ юманд тос түрхэх, тостой болгох; *машин тослох.*

ТОСЛУУЛАХ 1. тослохын үйлдүүлэх хэв; 2. тослогдох.

ТОСЛУУР тосолдог юм.

ТОСОГДОХ тосохын үйлдэгдэх хэв.

ТОСОРХОГ тос нүнжиг ихтэй, тосорхуу.

ТОСОРХУУ 1. тосорхог 2. тос мэт.

ТОСОХ 1. урдаас угтах, угтуулах; *тосч авах; тосч тулах; тосч хүлээх; тосч бэлтгэх; тосч гүйх;* 2. юм авахад зэхэх, бэлтгэх; *хоёр гараа тосох; хормой тосох; хорин ланеийн ембүүнд хормойгоо тосдог эзэж үү дээ* (дуу).

ТОСТ тос бий; **тост агь у р г а м а л** (нэг зүйл агь).

ТОСТОЙ тос бүхий; *тостой сүү; тостой буудаа.*

ТОСТОХ тостой болгох.

ТОСУУЛ тоссон юм.

ТОСЛУУЛАХ 1. тосохын үйлдүүлэх хэв; 2. тослогдох.

ТОТГО гэр байшингийн хаалганы дээд этгээд; *гэрийн тотгоор шагаав.*

ТОТГОР саад, хөндөл, саатуулах, боогдуулах юм; **саад тотгор** х о р ш.: *тотгорыг арилгах;* **тотгор болох** (саад хөндөл болох).

ТОТГОРДОХ тотгор хийх, тотгор тавих.

ТОТГОРЛОГДОХ тотгорлохын үйлдэгдэх хэв.

ТОТГОРЛОХ тотгор болох, саад болох.

ТОТГОРЛУУЛАХ 1. тотгорлохын үйлдүүлэх хэв; 2. тотгорлогдох.

ТОТЬ а м ь т а н ихэнхийн өд хурц өнгөтэй, хушуу монхор бөгөөд үзүүр нь доош матиран гахийсан, ой модонд сүргээр байх ба модны хонгилд үүрлэнэ, юманд их авирамтгай, аливаа юмны дуу чимээг дууриахдаа маш гайхамшигтай өөгөөд уг сурахдаа түргэн нэг зүйл шувуу.

ТОХИГҮЙ 1. тохь муутай, тав тух муутай; *тохигүй суух;* 2. төлөв аятай биш; *тохигүй зантай хүн; тохигүй айл.*

ТОХИЛОГ үзэмжтэй, цэвэр, аятайхан байдалтай, тохь сайтай; *тохилог айл; тохилог хүн; тохилог тосгон.*

ТОХИЛОХ тохьтой байх, тохьтой болох, тавлах, гухлах.

ТОХИЛУУЛАХ тохилохын үйлдүүлэх хэв.

ТОХИОЛ тохиох нь, учрал; **учрал тохиол** х о р ш.; *сайн муугийн тохиол.*

ТОХИОЛГОХ тохиохын үйлдүүлэх хэв, тохиоход хүргүүлэх, тохиолдуулах.

ТОХИОЛДОХ 1. тохиохын үйлдэлдэх хэв, тааралдах, учрах; *замд тохиолдсон албаны хүмүүс; ямар учир тохиолдсоныг мэдэхгүй;* 2. хүрэх. тусах; *өвчин тохиолдох.*

ТОХИОЛДУУЛАХ тохиолдохын үйлдүүлэх хэв, дайралдуулах; *их баярыг тохиолдуулан... наян насны ойг тохиолдуулан...*

ТОХИОХ тохиолдох, учрах, харгах; *ийм нэгэн явдал тохиожээ.*

ТОХИР бохир, тахир, бөгтөр; **бохир тохир** х о р ш.; **тохир хуруу** (сунгаж болохгүй хуруу); **тохир гар** (сунгаж болохгүй гар)

ТОХИРОЛ тохирох үйлийн нэр; *тохирол сайтай; тохирол муутай.*

ТОХИРОЛГҮЙ тохирохгүй.

ТОХИРОЛТОЙ тохирол сайтай.

ТОХИРОМЖ таарамж, нийлэмж, зохиромж,

ТОХИРОМЖГҮЙ тохирч зохирохгүй, нийцэхгүй, таарахгүй, тааламжгүй.

ТОХИРОМЖТОЙ нийлэмж, тохиромж сайтай, тааламжтай, таарамжтай, зохиромжтой.

ТОХИРОО тохирол, зохицоо, зохицол; *хээлтэгч хээлтүүлэгч малын тохироо.*

ТОХИРОХ нийцэх, таарах, зохицох, тэнцэх; *даргын тушаалд тохирно; наймаа тохирох; сэтгэл тохирох; хэлэлцээ тохирох; багшид тохирох хүн.*

ТОХИРОХГҮЙ нийцэхгүй, таарахгүй зохицохгүй, тэнцэхгүй.

ТОХИРУУЛ тохируулдаг юм.

ТОХИРУУЛАХ тохирохын үйлдүүлэх хэв, нийцүүлэх, тааруулах, зохицуулах, тэнцүүлэх; *сэтгэлд нь тохируулах; биед нь тохируулах.*

ТОХНИЛ тогтних үйлийн нэр; *тохнил сайтай; тохнил муутай.*

ТОХНИУЛАХ тохнихын үйлдүүлэх хэв.

ТОХНИХ түвшин амгалан, тайван болох; **тохних төвхнөх, тогтож тохних** х о р ш.

ТОХОГДОХ тохохын үйлдэгдэх хэв.

ТОХОЙ 1. гарын атгаал, богтсын нийлэх үе; *ширээ дээр тохойгоо битгий тавь! гараа тохойгоор нь нугалах;* 2. хувцасны ханцуйн мөн төр орчны газар; *дээлийн тохой цоорох;* 3. уртын хэмжээ; *наян тохой өндөр;* **үзүүр тохой** (тохойгоос дэлгэсэн гарын хурууны үзүүр хүрэх хэмжээ); **мухар тохой** (тохойгоос атгасан гарын дээд тал хүрэх хэмжээ); 4. усны тохойрч мухиран урссан газар; *голын тохой* ☆ **тохой татах, тал тохой татах** (бусдыг дотночлон хэлбийж өмөөрөх).

ТОХОЙЛДОХ тохойгоор тулах; *ширээ тохойлдож суув.*

ТОХОЙЛДУУЛАХ тохойлдохын үйлдүүлэх хэв.

ТОХОЙЛОХ тохойгоор хэмжих; *шагаачид модоо зоож газраа тохойлж байв.*

ТОХОЙЛУУЛАХ тохойлохын үйлдүүлэх хэв.

ТОХОЙРОХ 1. тохой болох; 2. тохойрч урсах.

ТОХОЙРУУЛАХ тохойрохын үйлдүүлэх хэв.

ТОХОМ эмээл, янгирцаг мэтийн дор жийрэглэн тохох юм; *эсгий тохом; даавуу тохом;* **тохом татах** (малын нуруунд тохом тохож даруулах); **тохмын хайдаг** (дөрөөний сурын халхавч).

ТОХООХ 1. тохохын үйлдүүлэх хэв; 2. томилж хүлээлгэх; *албан ажилд тохоох; тохоон томилох.*

ТОХОХ 1. эмээлийг морь малын нуруун дээр тогтоож бэхлэх; *эмээл тохох;* 2. юмыг юман дээгүүр бөгтөрч тавих; *дэвсгэрийг хашаан дээгүүр тохох;* 3. ш и л ж с э н бусдыг буруутгах, бурууга хүлээлгэх; *бурууг хүн дээр тохох.*

ТОХОШ 1. тэмээний атавч эмээл; *хивс тохош;* 2. тохом.

ТОХОШЛОХ тохош тохох.

ТОХОШЛУУЛАХ тохошлохын үйлдүүлэх хэв.

ТОХРОЛ тохрох үйлийн нэр, тохирол.

ТОХРОХ I. тохирох, нийцэх; 2. уул хэвтээ орох; *тэгвэл ингэж тохрох шив дээ.*

ТОХРУУЛАХ тохрохын үйлдүүлэх хэв.

ТОХУУ тоглоом хийж элэглэн шоолж наадах нь; **тоглоом тохуу, наадам тохуу** х о р ш *тохуу хийх; тохуутай хүн.*

ТОХУУЛАХ 1. тохохын үйлдүүлэх хэв; 2. тохогдох.

ТОХУУРХАХ тоглоом тохуу хийх, даажигнах, элэглэн наадах.

ТОХУУРХУУЛАХ тохуурхахын үйлдүүлэх хэв.

ТОХЬ I 1. байдал төлөв; *тохь сайтай; тохь муутай;* 2. тав, тух; **тав тохь, тохь тух** х о р ш; *тохь алдах.*

ТОХЬ II тэмээн хяруул гэдэг шувуу.

ТОХЬТОЙ аятай, таатай, тохь сайтай; *тохьтой хүн; тохьтой айл; тохьтой байр; тохьтой эд; тохьтой томоотой.*

ТОШГИРОХ шагшрах.

ТОШГИРУУЛАХ тошгирохын үйлдүүлэх хэв.

ТОШГИЧИХ байн байн тошгирох.

ТОШИГНОХ тошин ус, мөсөн дээгүүр хальж урсах; *гол тошигнох.*

ТОШИГНУУЛАХ тошигнохын үйлдүүлэх хэв.

ТОШИН мөсөн дорхи ус, мөсний завсраар дээш гарч мөсөн дээгүүр хальж урссан ус; *тошин гүйх.*

ТОШИНТОХ тошин гарах, тошин болох, тошинтой болох.

ТОШЛОГ у р г а м а л 1. исгэлэн жимсгэнэтэй, өргөстэй, жижгэвтэр бут; 2. мөнхүү жимсгэнэ.

ТӨВ I 1. дунд, гол; *хотын төвд суух;* **төв дунд** (яг дунд нь); **төвийг сахих** (аль ч талд оролгүй, цэх шударага байх); 2. ерөнхий, гол; *Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороо; Төв театр; төв цахилгаан мэдээ; төв цэцэрлэг;* **анхаарлын төвд** (онцлон анхаарч бий, анхаарлын голд); 3. төвлөсөн газар, суурин газар; *аймгийн төв; сумын төв; бригадын төв; төв орон нутгийн байгууллага;* **төв газар** (а. гол газар; б. суурин газар).

ТӨВ II түвшин, тайван, тохьтой, томоотой; **түвшин төв** х о р ш.; **төв хүн** (шударага зантай хүн); **төв зан** (томоотой зан); **төв үзэл** (үнэн үзэл); **төв санаа** (шударага санаа); **сэтгэлийг төв байлгах** (сэтгэл түвшин байлгах).

ТӨВГӨР товгор, овгор, гүвгэр; *төвгөр газар.*

ТӨВГӨРДӨХ хэтэрхий төвгөр болох.

ТӨВГӨРЛӨХ төвгөр болгох, товгор болгох.

ТӨВИЙХ төвгөр болох; *төвийсөн газры нь дарж өгөх хэрэгтэй.*

ТӨВЛӨХ 1. төв, гол болох; *сумын төвлөж байгаа газар;* **төвлөн удирдах зарчим** (товчлон удирдах зарчим); 2. нэгэн төвт бөөгнөрүүлэх, нэгэн төвт захирах.

ТӨВЛҮҮЛЭХ төвлөхийн үйлдүүлэх хэв.

ТӨВӨГНӨХ төвгөр юмны үргэлжлэн хөдлөх.

ТӨВӨЛЗӨХ төвгөр юмны байн байн хөдлөх.

ТӨВӨН төвөнх, төвөнхий.

ТӨВӨНТӨХ бамбай булчирхай томрох өвчин.

ТӨВӨНХ цагаан хоолойн дээд хэсэг, төвөн, төвөнхий; **төвөнхийн авиа** (өгүүлэхэд төвөнх оролцох авиа).

ТӨВӨНХИЙ төвөн, төвөнх.

ТӨВХНӨХ орон гэрийн байдлыг сэтгэлд тааламжтай засах, тохируулах; **тохних төвхнөх** х о р ш.; *нүүж буусаар төвхнөж чадав уу?*

ТӨВХНҮҮЛЭХ төвхнөхийн үйлдүүлэх хэв.

ТӨВХНҮҮН төвхнөсөн байдал сайтай; **тохилог төвхнүүн** х о р ш..

ТӨГИЙ тэргний тоног, тэргэнд хөллөх морины хүзүүн дээгүүр давуулж аралтай холбох махир мод.

ТӨГӨЛДӨР 1. төгс, юмны бүрэн гүйцэд бүхий: **бүрэн төгөлдөр, хүчин төгөлдөр** х о р ш.; *ухаан төгөлдөр; утга агуулга төгөлдөр; авьяас төгөлдөр;* 2. бүрэн хүчинтэй; *хүчин төгөлдөр; энэ хууль нь нийтлэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөрт үзэж дагаж шийтгүүлнэ.*

ТӨГРӨГ 1. дугараг юм; 2. зуун мөнгөнд гаацуулан гаргасан зарцуулах цаас зоос; **мөнгө төгрөг** х о р ш..

ТӨГРӨГЛӨХ дугараглах, дүгрэглэх, дугуй болгох.

ТӨГС дутуугүй бүрэн гүйцэд; **төгс сар** (сарны зурхайн ёсны нэмэх тасрахгүй гучин хоногтой сар); **төгс үнэн** (бүрэн үнэн, хамгийн үнэн, туйлын үнэн); **авьяас билиг төгс** (маш оюун билигтэй); **төгс эрх** (бүрэн эрх); **төгс ураг** (төрсөн эцэг эх).

ТӨГСВӨР 1. бүрдэл болсон; 2. дуусвар, төгсгөл; *яриагаа үүгээр төгсвөр болгоё.*

ТӨГСГӨЛ үйл явдлын эцэс, дуусгал; *хурлын төгсгөл; төгсгөлийн хуралдаан;* **төгсгөлийн үг** (юмны эцэст дүгнэж хэлсэн үг).

ТӨГСГӨХ төгсүүлэх, төгсөхөд хүрүүлэх, дуусгах.

ТӨГСӨЛ бүрдэл, дуусал, эцэс; *хуралдааны ажил төгсөл болов.*

ТӨГСӨХ 1. юмны барагдаж дуусах; 2. ажил үйлдвэр дуусч гүйцэх; 3. аливаа хэрэглэхүүн гүйцэд төгөлдөр болох.

ТӨГСҮҮЛЭХ төгсөхийн үйлдүүлэх хэв, төгсгөх; *сургуулий нь төгсүүлэхийг хичээж байна.*

ТӨГЦӨГ I түлж үлсэн модны үлдэгдэл, үзүүр; *төгцөг мод.*

ТӨГЦӨГ II хөгшрөнгө болсон нь; **хөгшин төгцөг** х о р ш.; *хөгшин төгцөг болтлоо томоожихгүй яасан хүн бэ?*

төд даруй, саяа; *төд явсан; төд ирнэ; хүрсэн төд; очсон төд эргэнэ.*

төдгүй базаахгүй, барагтайхан, тааруухан; *төдгүй ястай эд; бие нь төдгүй байна.*

төдий 1. өдий гэж тэдгээрийг заах үг; *шал дэмий юманд төдий цаг барахын хэрэг юу байна даа;* 2. тийм; *хэл сурна гэдэг бол төдий ч амархан хэрэг биш.*

төдийхөн баахан төдий, тиймхэн, иймхэн.

төдөг төдүүл I.

төдүүл I 1. өмд зэргийн юмны оосор тогтоох сэнж; 2. юмны уулзар нийлсэн газарт бэхэлж тавьсан нөхөөс мэт зүйл.

төдүүл II өдүүл гэж тэдгээрийг заах үг; *төдүүлээ хайшаа явах юм бэ?*

төл мал гөрөөсний үр зулзага; *шөлөөр цадаж, төлөөр баяжна* х у у ч; **төл авах** (малын үржил авах); **төл сайтай** (үржил олонтой); **төл муутай** (үржил муутай); **төл сайн авах** (төл нь гарз хорогдолгүй өсөх).

төлбөр өр зэргийн оронд өгөх зүйл; **өр төлбөр** х о р ш.; **төлберт орох** (төлбөл зохих эд юм их болох).

төлжих I малын төл сайнаар өсөх; *мал төлжсөөр өдий олон болов.*

төлжих II амьтан юмны улмаар өсч их болох; тэвээрч таргалах, нөхөж ургах.

төлжрөх юмны төлжиж дээрдэх, өсөх.

төлжүүлэх төлжихийн үйлдүүлэх хэв.

төллөлт төллөх үйлийн нэр. төллөх явц; *мал төөллөлтийн ид үеэр сэлгүүцэн явдаг танхай этгээд байж болохгүй.*

төллөх амьтан, мал үр зулзагаа гаргах; *хонь төллөх цаг; мал төллөх.*

төллүүлэх төллөхийн үйлдүүлэх хэв.

төлөв юмны янз байдал; *тиймэрхүү төлөвтэй байсан юм;* **хэтийн төлөв** (алсын байдал): **их төлөв** (ихэнх нь, дийлэнх нь); **гол төлөв** (их төлөв); **бараг төлөв** (их төлөв); **төлөв зэхий** (хүний зан авир тогтууригүй); **төлөв томоо** (төлөв байдал); **төлөв хүн** (томоотой, түвшин байдалтай хүн).

төлөвгүй 1. төлөв муутай, төлөв зэхий; *төлөвгүй хүн;* 2. янз байдал үгүй; *энэ өдөр, нар гарах төлөвгүй байна;* 3. өөрчлөгдөх шинжгүй; *засрах төлөвгүй; өөдлөх төлөвгүй.*

төлөвжих хүний байдал, төлөв томоотой болох.

төлөвжүүлэх төлөвжихийн үйлдүүлэх хэв.

төлөвлөгөө 1. хийж гүйцэтгэх ажил үйлдвэрийн урьдчилсан сэдэв, төсөл, төсөв; *ажлын төлөвлөгөө; жилийн төлөвлөгөө; гурван жилийн төлөвлөгөө; таван жилийн төлөвлөгөө; хэтийн төлөвлөгөө; улирал сарын төлөвлөгөө; нарийвчилсан төлөвлөгөө; календарьчилсан төлөвлөгөө; ардын аж ахуйг хөгжүүлэх төлөвлөгөө; соёл гэгээрлийн талаар гүйцэтгэх ажлын төлөвлөгөө; аж үйлдвэрийн төлөвлөгөө; төлөвлөгөө бол хууль; төлөвлөгөөний хэлтэс;* **төлөвлөгөөний гүйцэтгэл** (төлөвлөгөөний биелэлт); 2. алив хийж байгуулах, цогцлох юмны зураг; **зураг төлөвлөгөө** х о р ш.; *барилгын зураг төлөвлөгөөг гаргуулж авав; зураг төлөвлөгөөний газар.*

төлөвлөгөөгүй төлөвлөгөө зохиодоггүй; *хөрөнгөтөн орны төлөвлөгөөгүй аж ахуй.*

төлөвлөгөөжилт төлөвлөгөөжих үйлийн нэр.

төлөвлөгөөжих төлөвлөгөөтэй болох.

төлөвлөгөөжүүлэлт төлөвлөгөөжүүлэх үйлийн нэр.

төлөвлөгөөжүүлэх 1. төлөвлөгөөжихийн үйлдүүлэх хэв; 2. төлөвлөгөөтэй болгох.

төлөвлөгөөт төлөвлөгөө бий.

төлөвлөгөөтэй төлөвлөгөө бүхий; *төлөвлөгөөтэй аж ахуй.*

төлөвлөгөөч төлөвлөгөө хийгч этгээд, төлөвлөгч.

төлөвлөгч төлөвлөх этгээд, төлөвлөөч.

төлөвлөх 1. үйл ажлыг үүсгэхийн өмнө тэр ажлыг хэрхэн ямар арга журамтайгаар гүйцэтгэх тухай тоймлон боловсруулах; *ирэх жил хийх ажлаа одоогоос эхлэн нарийн бодож төлөвлөх нь чухал; нэгэнт нягталж боловсруулсан төлөвлөгөөг заавал биелүүлэх хэрэгтэй;* 2 ямар нэгэн хэмжээгээр тоймлон мэдэх: *тэр хүний санааг би төлөвлөж байна.*

ТӨЛӨВЛҮҮЛЭХ төлөвлөхийн үйлдүүлэх хэв.

ТӨЛӨВТЭЙ 1. төлөв бүхий, томоо бүхий; *багаасаа их төлөвтэй өссөн хүүхэд байгаа юм;* 2. янзтай, байдалтай; *энэ ажил сайн дүнтэй ажил болж чадахгүй төлөвтэй.*

ТӨЛӨГ I хоёр настай хонь; *эр төлөг; охин төлөг.*

ТӨЛӨГ II мэрэг; **мэрэг төлөг** х о р ш.; *төлөг үзэх; төлөг тавих; төлөг үзэгч түмэн худалч, зальд үзэгч жаран худалч* з ү й р.

ТӨЛӨГДӨХ I мэрэглэх.

ТӨЛӨГДӨХ II төлөхийн үйлдэгдэх хэв

ТӨЛӨГДҮҮЛЭХ төлөгдөхийн үйлдүүлэх хэв.

ТӨЛӨГЛӨХ төлөгдөх.

ТӨЛӨГЛҮҮЛЭХ төлөглөхийн үйлдүүлэх хэв.

ТӨЛӨГЧ I төлөг үзэгч, мэрэглэгч; *төлөгч малд; мэргэн төлөгч.*

ТӨЛӨГ II төлөх этгээд; *өр төлөгч; татвар төлөгч.*

ТӨЛӨГЧ III: **төлөгч өвс** у р г а м а л янз **хамхагтай** адил болоод бут бутаар ургана, иш маш шулуун; үзүүртээ улаан цэцэгтэй ургамал.

ТӨЛӨӨ I. орлосон этгээд; *эцгийн төлөө хөвгүүн ирэв; ахын төлөө дүү нь хэлэлцэв;* **төлөөний түшмэл, төлөөний хүн** (орлож, төлөөлөн яваа түшмэл); **төлөөний нэр** (нэр үг, тэмдэг үг, тооны үг зэргийг орлуулан өгүүлэх үг; *заах төлөөний үг; биеийн төлөөний үг*); 2. тулд; *эх орны төлөө тэмцэл; миний төлөө бахгай санаа зовоорой; таны эрүүл мэндийн төлөө энэ хундагыг дэвшүүлье!*

ТӨЛӨӨЛӨГЧ улс, албан газрын буюу ардын нэрийн өмнөөс үүрэг даалгагдсан төлөөний хүн; *засгийн газрын төлөөлөгч.*

ТӨЛӨӨЛӨХ орлох, үйл явдлыг төлөөнөө гүйцэтгэх; *улсыг төлөөлөх; ахыгаа төлөөлөх.*

ТӨЛӨӨЛҮҮЛЭХ төлөөлөхийн үйлдүүлэх хэв.

ТӨЛӨӨНӨӨ ямар нэгэн юмны орноос; *төлөөнөө гарын үсэг зурав; түүний төлөөнөө явж байна.*

ТӨЛӨӨС өр төлбөр; **өр төлөөс** х о р ш.

ТӨЛӨӨСЛӨХ 1. юм хумыг худалдан авахад үнийг бэлэн өгөхгүйгээр хэлэлцэж авах; 2. төлөөлөх.

ТӨЛӨӨСЛҮҮЛЭХ төлөөслөхийн үйлдүүлэх хэв.

ТӨЛӨӨСӨН 1. ор; 2. өр төлөөс.

ТӨЛӨХ юмны орыг юмаар буюу мөнгөөр өгөх нөхөх; *өр төлөх; алба төлөх; хөлс төлөх; орон сууцны хөлс төлөх.*

ТӨЛҮҮЛЭХ төлөхийн үйлдүүлэх хэв; *өр төлүүлэх; шамшсан зүйлийг төлүүлэх.*

ТӨМБИЙЛГӨХ төмбийхийн үйлдүүлэх хэв, төмбөгөр болгох.

ТӨМБИЙХ төмбөгөр болох.

ТӨМБӨГӨР томбогор, овгор; *төр төмбөгөр, ёс ёмбогор* з ү й р.

ТӨМӨР 1. хувилахуй ухааны махбод болох мөнгөлөг өнгөтэй хүнд төмөрлөг; ган, ширмийн гол бүрэлдэхүүн нь болно; *ган төмөр; хар төмөр; цагаан төмөр; төмөр хайлах; төмөр ширээх; төмрийн сайныг давтаж мэддэг, нохрийн сайныг ханилж мэддэг; төмрийн сайн зэвэрдэггүй, төрлийн сайн мартагддаггүй* з ү й р; **төрөөгүй хүүхдэд төмөр өлгий бэлдэх** (юмыг яагаа ч үгүй байхад урьдаас зэхэж бэлтгэх); **төмрийн хүдэр** (төмрийн хольц бүхий чулуулаг); **төмрийн дархан** (төмрөөр юм хийдэг мэргэжилтэн, уран); **төмрийн баас** (төмрийн хүдрийг хайлуулж төмрийг ялган аваад үлсэн зүйл, хаягдал, ялгадас); **төмрийн хонд** (улаан хүрэн өнгийн нэг зүйл будаг); **төмрийн үе** (эрт дээр цагт хүмүүс төмөр хэрэглэх болсон цаг); 2. төмрөөр хийсэн юм; *төмөр хувин; төмөр хүрз; төмөр лааз; төмөр зуух;* **төмөр зам** (галт тэрэг явах зам төмөр; *төмөр замаар явах);* **зам төмөр** (дэр модонд бэхлэн хийсэн, ган цувимал зам, мөн цувимал зам дээгүүр галт тэрэгний дугуй өнхрөн явна); **төмөр замчин** (төмөр зам, галт тэрэгний ажилчин); **төмөр маншуу** (төмөр дэлдэх том алх); **төмөр хуур** (аманд тулгуулж хуруугаар хөндөж дуугаргах хөгжмийн зэвсэг); **төмөр мэт** (маш хатуу; *цэргийн төмөр мэт хатуу сахилга бат*).

ТӨМӨРДӨХ 1. юмыг төмөрлөх; 2. төмөртэй юмны төмөр юманд тулж хавирах; 3. хэтэрхий төмөр болох; 4. х у у ч и р с а н гинжлэх дөнгө зүүх.

ТӨМӨРДҮҮЛЭХ төмөрдөхийн үйлдүүлэх хэв.

ТӨМӨРЛӨГ гялгар өнгөтэй, давтагдах сунахдаа хялбар, дулаан ба цахилгааныг дам-

жуулахдаа сайн. их төлөв хатуу эрдэс; *төмөрлөгийн үйлдвэр;* **эрхэм төмөрлөг** (алт, мөнгө, цагаан алт зэрэг); **өнгөт төмөрлөг** (зэс, тугалга, цайр зэрэг); **хар төмөрлөг** (ган, ширэм зэрэг).

ТӨМӨРЛӨХ төмрөөр бүрэх, бүрхэх; *байшин төмөрлөх; пийшин төмөрлөх.*

ТӨМӨРЛҮҮЛЭХ төмөрлөхийн үйлдүүлэх хэв.

ТӨМӨРЧ (ИН) төмрийн дархан хүн; *төмөрчний хөөрөг; төмөрчний алх дөш; төмөрчний газар.*

ТӨМПӨН юм хийх балдгар хэлбэртэй сав; *гуулин төмпөн; сиян төмпөн; төмөр төмпөн.* • **ТӨМСӨГ**

ТӨМС I у р г а м а л цардуул ихтэй, бөөм үндэс бүхий нэгэн зүйлийн иддэг ногоо; *төмс тарих; төмс хураах;* **төмсний гурил** (төмсөөр хийсэн гурил); **цагаан төмс** у р г а м а л (сарааны цэцгийн- чихэрлэг амттай, том булцуун үндэс); 2. ц э э р л э с э н засаа; **төмс засаа** х о р ш.

ТӨМСТЭЙ төмс бүхий; *төмстэй хуурга; төмстэй хоол.* **ТӨМСТЭЙ ГҮҮ**

ТӨНХЛӨГ төнхсөн нь; *малтлага төнхлөг.*

ТӨНХӨХ 1. ямар нэгэн юмны дотор талыг ухах, малтах, хөндийлөх; **ухах төнхөх** х о р ш.; 2. ш и л ж с э н өөчлөх, оролдох, амар үл байлгах; *хүнийг ямагт ухчлан төнхөж ууры нь хүргэж байх ямар хэрэг байна.*

ТӨНХҮҮЛЭХ төнхөхийн үйлдүүлэх хэв.

ТӨӨ эрхий хуруугны үзүүрээс дунд хуруугны сунгасан үзүүр хүртлэх хэмжээ;.

ТӨӨЛӨГДӨХ төөлөхийн үйлдэгдэх хэв.

ТӨӨЛӨХ 1. төөгөөр хэмжих; 2. төөлүүрээр хэмжих.

ТӨӨЛҮҮЛЭХ 1. төөлөхийн үйлдүүлэх хэв; 2. төөлөгдөх.

ТӨӨЛҮҮР бие хэмжих хэмжээ; ☆ **х у у ч и р с а н төөлүүрт орох** (эрийн насанд хүрэх): **төөлүүр хорхой** (төөч хорхой).

ТӨӨНӨ халуун юмаар түлж, хайрч эмчлэх арга; *төөнө тавих.*

ТӨӨНӨГДӨХ төөнөхийн үйлдэгдэх хэв.

ТӨӨНӨРӨХ 1. нэгэн газар халуу оргих; 2. халуу оргиж өвдөх.

ТӨӨНӨРҮҮЛЭХ төөнөрөхийн үйлдүүлэх хэв.

ТӨӨНӨХ 1. халаах, халуу оргиулах; *ар нуруунаас нар төөнөж байна;* 2. төөнө тавих.

ТӨӨНҮҮЛЭХ 1. төөнөхийн үйлдүүлэх хэв; 2. төөнөгдөх.

ТӨӨРӨГ заяа, хувь, зохиол, аз; *чингэж орхиод л төөргөө харъя; төрсөн өдрийн төөрөг, гарсан өдрийн гариг мэдэг гээд явав;* **төөргөө үзье** (азаа үзье).

ТӨӨРӨГДӨЛ төөрөгдөх үйлийн нэр; *ард түмнийг шашны төөрөгдлөөс салгах.*

ТӨӨРӨГДӨХ төөрөхийн үйлдэгдэх хэв; *мухар сүсэгт төөрөгдөх.*

ТӨӨРӨГДҮҮЛЭХ төөрөгдөхийн үйлдүүлэх хэв; *хүмүүсийг төөрөгдүүлэх.*

ТӨӨРӨЛ төөрөх үйлийн нэр; *төөрөлд оруулах; төөрөлд учруулах.*

ТӨӨРӨЛДӨХ төөрөхийн үйлдэлдэх хэв.

ТӨӨРӨХ 1. зүг чиг алдах, буруу замаар орох; *цасан шуурганд төөрөх; төөрч төөрч төрөлдөө* з ү й р; 2. бодлого самуурах; *санаа төөрөх; ухаан төөрөх.*

ТӨӨРҮҮЛЭХ төөрөхийн үйлдүүлэх хэв, төөрөхөд хүргүүлэх.

ТӨӨЧ: төөч хорхой а м ь т а н толгой бөгс хоёр нь нийлж бие нь хөндийрөн явах нэг зүйл өт, төөлүүр хорхой ч гэнэ.

ТӨР 1. улсын засаг; **засаг төр** х о р ш.; *ардын төр; төр барих; төр булаах; хувьсгалт төр; төр-түмэн олныхоо төлөө байх ёстой; төр түмэн нүдтэй, төрсөн бие хоёр нүдтэй, төр төмөр нүүртэй* з ү й р; 2. улс; **улс төр** х о р ш.; *улс төрийн байдал; төрийн бодлого; төрийн хэрэг; төрийн байгуулал; төрийн тэмцэл; улс төр-эдийн засаг; улс төрийн нам; төрийн зүтгэлтэн;* **төрийн далбаа** (улсын далбаа); **төрийн дуулал** (улсын дуулал); **төрийн ятга** (язгуур этгээд өргөн, үзүүрийн этгээд шувтан долоон чавхдастай хөгжмийн зэвсэг); **төрийн хатан, төрийн авхай** х у у ч и р с а н (төрийн жүн вангийн охин); 3. ёс, хууль, цааз; **ес төр** х о р ш.; *төр эрхийн асуудал; төр төмбөгөр, ёс ёмбогор* з ү й р; **төр ёстой** (тогтоосон ёс хуультай); **хурим төр** (хурим хийх дүрэм ёс); 4. нэр сүр,

алдар; **нэр төр** х о р ш . ; *хөдөлмөр бол нэр төрийн хэрэг мөн; нэр төрийн хойноос хөөцөлдөх.*

ТӨРӨЛ 1. төрөх үйлийн нэр; *төрөл төрөгсөд;* **хойт төрөл** х у у ч и р с а н (шашны ёсонд: үхээд дахин төрдөг **гэх номлол**); **урьд төрөл** х у у ч и р с а н (шашны ёсонд: төрөхийн өмнө аливаа хүн, адгуус, хорхой, шавьж зэрэг амьтан байсан гэгчийг); **төрөл арилжих** х у у ч и р с а н (а. үхэх, б. шашны ёсонд: төрлөө солих, хувилан төрөх); 2. садан; **садан төрөл, ураг төрөл** х о р ш . ; *хүрим хийхэд садан төрлийн хүмүүс цөм цугларив;* **цусан төрөл** (эхийн төрөл); **ясан төрөл** (эцгийн төрөл): **төрлийн ах** (нэг овгийн ах); **төрлийн дүү** (нэг овгийн дүү); **төрөл хэл** (гарал үүсэл нь нэг буюу ойр хэл); 3. амьтан ургамлын язгуур, гарлын ялгавар; **төрөл анги** х о р ш . ; *мигуйн төрөл; намуу цэцгийн төрөл;* 4. ш и л ж с э н анги, зүйл, янз; *төрөл төрлөөр нь ялгах; нэг төрлийн эд бараа.*

ТӨРӨЛТӨН төрөлхтөн.

ТӨРӨЛХ 1. төрөхийн, угийн, угаас; *төрөлхийн муухай зантай хүн; төрөлхийн дүлий; төрөлхийн сохор;* 2. төрсөн нутгийн, өөрийн орны; эцэг эхийн; **төрөлх хэл** (төрсөн орны хэл, төрмөгц сурсан хэл).

ТӨРӨЛХТӨН амьтан, төрөн гарсан амьтан; **хүн төрөлхтөн** (хүн болж төрөгсөд); *бүх дэвшилт хүн төрөлхтөн энх тайвныг хамгаалан зогсож байна;* **адгуусан төрөлхтөн** (адгуус мал).

ТӨРӨХ 1. эм амьтнаас үр гарах; *хүү төрсөн байна; хүүхэд төрөх; төрөхийн өмнө;* **төрсөн эцэг эх** (өөрийг төрүүлсэн эцэг эх); **төрсөн нутаг** (мэндэлж өссөн нутаг); **төрсөн хүү** (өөрийн төрүүлсэн хүү); **төрсөн ах дүү** (нэг эцэг эхээс гарсан ах дүү); **төрсөн газрын шороо алт** х у у ч . ; 2. бий болох, гарч ирэх, үүсэх; *ямар учраас тийм бодол төрөв? зориг төрөх; уйтгар төрөх;* **төрсөн он** (мэндэлсэн он); **төрсний зуун жилийн ой** (мэндэлсний зуун жилийн ой); **аж төрөх** (амьдрах);

ТӨРҮҮЛЭХ 1. төрөхийн үйлдүүлэх хэв; 2. сургах, хүмүүжүүлэх; *Монгол Улсын их сургууль жил бүр олон мэргэжилтнийг төрүүлэн гаргаж ирэв.*

ТӨРХ 1. биеийн хэв, маяг, хэлбэр, галбир; *төрх сайтай адуу;* 2. авир, аяг; **төрх муутай хүн** (муу зантай хүн).

ТӨРХГҮЙ 1. зан авир муу; 2. зүггүй, дүрсгүй; *төрхгүй хүүхэд.*

ТӨРХЖИХ томоожих, төлөвжих; *өдий хүртлээ төрхжихгүй яасан амьтан бэ.*

ТӨРХЖҮҮЛЭХ төрхжихийн үйлдүүлэх хэв.

ТӨРХӨМ эхнэрийн өөрийн төрөл садан, **гэр** газар нь; **төрхөмдөө буцах** (эрээс салж гэртээ харих).

ТӨРХӨМЛӨХ төрхөмдөө айлчлан очих.

ТӨРХӨМСӨГ төрхөмдөө элэгсэг.

ТӨРХӨМСӨХ төрхөмдөө элэгсэх.

ТӨРХӨМСҮҮЛЭХ төрхөмсөхийн үйлдүүлэх хэв.

ТӨРХТЭЙ томоотой, төлөв; *төрхтэй яваарай.*

ТӨС 1. төсөө, царай дүр адил; *та хоёр их төстэй юм;* 2. байдал, маяг ойролцоо.

ТӨСГҮЙ огт адилгүй, ойролцоо биш, ондоо.

ТӨСЛӨХ 1. төсөөтэй болох, адил шиг болох; *одоо л төсөлж байна;* 2. я р и а муухан мэдэх, барагтайхан таних; *бичиг төслөх төдийхөн; энэ хүнийг би төслөхгүй юм байна.*

ТӨСЛҮҮЛЭХ төслөхийн үйлдүүлэх хэв.

ТӨСӨВ 1. тойм, багцаа, төлөвлөгөө; хүн, албан байгууллага, улсаас ямар нэгэн тодорхой хугацаанд зарцуулах зарлага, оруулах орлогыг таацуулан бодсон бүдүүвч төлөвлөгөө; *төсөв хийх; жилийн төсөв; орлогын төсөв; зарлагын төсөв; төсвийн хууль; төсвөөс хэтрэх; төсвийн комисс; төсвийн зүйл анги.*

ТӨСӨВЛӨГДӨХ төсөвлөхийн үйлдэгдэх **хэв.**

ТӨСӨВЛӨЛ төсөвлөх үйлийн нэр.

ТӨСӨВЛӨХ 1. төлөвлөх, тоймлох; 2. төсөв хийх; **төсөвлөсөн данс** (албан газрын орлого зарлагын талаар урьдчилан төлөвлөж бодсон данс).

ТӨСӨВЛҮҮЛЭХ 1. төсөвлөхийн үйлдүүлэх хэв; 2. төсөвлөгдөх.

ТӨСӨГ 1. төсөр, ойр; **ойр төсөг** х о р ш . ; *ойр төсөг эмээлтэй морь байх болов уу?* 2. хямд; **хямд төсөг** х о р ш . ; *хямд төсөг мал дайралдвал худалдан авах ажээ;* 3. саявтар, ойрын үед; *ойр төсөг тийм юм дуулдсангүй.*

ТӨСӨӨ I 1. төс, царай дүр адил; 2. байдал, маяг ойролцоо; *түрүүчийн хэрэгтэй тон төсөөтэй байна.*

ТӨСӨӨ II төшөө, эв дүй муутай; *ойрын хэдэн жил уурга бариагүй их төсөө болжээ.*

ТӨСӨӨГҮЙ I адилгүй, ойролцоо ч биш.

ТӨСӨӨГҮЙ II элдэвт зохисгүй, аливаа хэрэг явдлыг мэдэх төсөөлөхгүй.

ТӨСӨӨЛӨХ 1. юмны учрыг төлөвлөн мэдэх; *урьд нь чингэж төсөөлж байсан нь яг таарчээ;* 2. муухан чадах, мэдэх; *бичиг төсөөлөх.*

ТӨСӨӨЛҮҮЛЭХ төсөөлөхийн үйлдүүлэх хэв.

ТӨСӨӨРӨХ мартаж эв дүйгүй болох, төсөөрөх; *бөмбөг цохихгүй удаад төсөөрч орхисон байв.*

ТӨСӨӨТЭЙ адил, ойролцоо, төстэй.

ТӨСӨР 1. төсөг, баахан ойр: **төсөр дөхөм** хорш.; 2. хямд; **хямд төсөр** хорш.; *хямд төсөр үнэтэй юм олж авах юм сан.*

ТӨСӨРГҮЙ 1. ойргүй, хол; 2. эрт, урьд.

ТӨСӨХ урьдчилан бодох, бүдүүвчлэн ойлгох, тоймлох.

ТӨСТЭЙ адилшиг, ойролцоо.

ТӨХӨМ хотгор, хонхор газар; **төрд элч ширүүн, төхөмд зараа ширүүн, төмөрт хуурай ширүүн** (ертөнцийн гурван ширүүн).

ТӨХӨӨ 1. *төсөө; энэ хоёр төхөөтэй харагдав;* 2. томоо; *тэр гуай төхөөтэй хүн шүү.*

ТӨХӨӨРӨГ төхөөрсөн нь, бэлтгэл, төхөөрөмж; *төхөөрөг ихтэй явдал.*

ТӨХӨӨРӨМЖ алив юмыг хийж бэлтгэхэд урьдчилан бэлтгэсэн, зэхсэн, төхөөрсөн юм, бэлтгэл; **тоног төхөөрөмж** хорш.; *барилгын төхөөрөмж; худгийн төхөөрөмж; үйлдвэрийн төхөөрөмж.*

ТӨХӨӨРӨХ 1. зэхэх, бэлдэх; *аянд юм төхөөрөх;* 2. цээрлэсэн алах, нядлах; *үхэр төхөөрөх.*

ТӨХӨӨРҮҮЛЭХ төхөөрөхийн үйлдүүлэх хэв.

ТӨЧНӨӨН төдий чинээ гэж тэдгээрийг заах үг; *нөхөр Бадрах мөн төчнөөн тооны мал харицулж байна;* 2. ийм хэмжээтэй, тийм удаан; **өчнөөн төчнөөн** хорш.; *өчнөөн төчнөөн болтол хараад ирсэнгүй; төчнөөн удтал чи хаа байв?*

ТӨШӨӨ эв, дүй муутай; *гар төшөө болох.*

ТӨШӨӨРӨХ төсөөрөх.

ТРАЕКТОРИ сумны явах муруй зам.

ТРАКТОР юм чирэхэд зориулж үйлдсэн өөрөө явах машин; *трактор засвар хийх; трактораар чирүүлэх; тракторын бригад.*

ТРАКТОРДАХ трактораар ажиллах.

ТРАКТОРЖИХ трактортай болох, трактораар хангагдах.

ТРАКТОРЖУУЛАХ тракторжихын үйлдүүлэх хэв.

ТРАКТОРЧ трактор жолооч; *нэгдлийн тракторч.*

ТРАКТОРЧЛАГДАХ бүрэн тракторжих, трактораар бүрэн хангагдах.

ТРАМВАЙ хот дотор явах цахилгаан тэрэг; **трамвайны зам** (трамвай явах төмөр зам).

ТРАПЕЦ хоёр тал нь зэргэд, хоёр тал нь зэргэд биш дөрвөн өнцөгт.

ТРЕСТ ажил төрлөөрөө төстэй, ганц удирдлага бүхий хэд хэдэн албан газрын нэгдэл; *барилгын трест; трестийн захиргаа.*

ТРОЛЛЕЙБУС зам төмөргүй явах цахилгаан тэрэг.

ТУГ I 1. ишинд зохих өнгийн бөс уяж намиран хийсгэх тэмдэг; **туг далбаа** хорш.; *улсын туг; туг босгох; туг хатгах; туг барич; туг далбаа нь хийсээд, тон ч сайхан харагдана* (дуу); **жанжин туг** (цэргийн гол туг); **туг тайх** хуучирсан (а. дайсныг дарсны дараа жанжин тэргүүлэн бүх цэргүүд тугт мөргөх; б. дайснаас олзлогдсон хүнийг тугийн өмнө хороох); 2. шилжсэн удирдлага, сургаал; *Марксизм-ленинизмийн тугийн дор;* 3. шилжсэн сод, тэргүүн; *тэдний туг нь.*

ТУГ II бут, багц, бөөм хэсэг; *туг үс; туг сүүл; туг өвс;* ☆ **туг ширээ** (тэмээний бөхний эгц босоог; *туг ширээ бөхтэй хүрэн ат*);

ТУГААР саяхан

ТУГААРХАН саяхан.

ТУГАЛ үнээ, заан, хандгай зэрэг адгуусны төл; *туяан цагаан таягаа тулж, тугал олон одон сургээ туув* (шүлэг); *тугалын зэл; туга-*

лын хашаа; тугалын арьс; ☆ **тугал улаан болох** (хүүхдийн бие зуны наранд ихэд шарагдах).

ТУГАЛГА (Н) саарал өнгөтэй, маш хүнд, зөөлөн төмөрлөг; *хар тугалга; тугалган жад шантрахдаа амархан, туйлбаргүй хүн буцахдаа амархан* з ү й р; **цагаан тугалга** (цайвар өнгөтэй бөгөөд зөөлөн төмөрлөг мөн хувилахуй ухааны нэг зүйл махбод); **тугалган цаас** (а. цаас мэт нимгэлсэн тугалга; б. тугалга мэт өнгөтэй нэг зүйл цаас); **хайлсан тугалга шиг** (маш элдэг зөөлөн зантай).

ТУГАЛГАДАХ тугалгаар гагнах, битүүлэх, тугалгаар зайлах; *тогоо тугалгадах; хувин тугалгадах.*

ТУГАЛГАТ тугалга бий, тугалгатай.

ТУГАЛГАТАЙ тугалга бүхий; *тугалгатай газар.*

ТУГАЛЛАХ үнээ тугалаа гаргах; *үнээ тугаллах.*

ТУГАЛЛУУЛАХ тугаллахын үйлдүүлэх хэв.

ТУГАЛМАЙ амьтны эврийн доторхи яс.

ТУГДАМ ордон, өргөө; *төрийн тугдам; ламын тугдам; ноёны тугдам.*

ТУГНАЛ тугнах үйлийн нэр.

ТУГНАХ эмийг тун тунгаар болгох, тугнуураар хувааж хэмжих; *эм тугнах.*

ТУГНУУЛАХ тугнахын үйлдүүлэх хэв.

ТУГНУУР тунгийн халбага, талхан эмийг хэмжих бяцхан халбага.

ТУГУЙ ганц модоор тавьсан гүүр.

ТУГТАМ шинэ, тулгар, сая бий болсон нь; **шинэ тугтам, тугтам тулгар** х о р ш.; *шинэ тугтам өсөн хөгжиж яваа аж ахуй.*

ТУГЧ туг баригч.

ТУЖ 1. турш, дуусан; *өдөр туж; шөнө туж;* 2. үргэлж, нэлэнхүй, нэлэнхүйдээ; *туж хар модтой газар; туж олон давхар байшинтай гудамж.*

ТУЖРАГА ухмал их модон аяга.

ТУЖРАХ гэр баян, ураг тутам найртай болох.

ТУЙВАЛЗАХ туйвганах, ганхалзах, дайвалзах; *салхинд туйвалзах.*

ТУЙВАЛЗУУЛАХ туйвалзахын үйлдүүлэх хэв.

ТУЙВАН I у р г а м а л намуу цэцгийн намын ургамал, цагаан буюу шар цэцэгтэй, сарвагар буюу гонзгой навчтай өвс.

ТУЙВАН II хүнийг жанчихад зориулсан нарийн торлог.

ТУЙВАНДАХ туйвангаар жанчих

ТУЙВГАНАХ хөл гуйвалзах, ганхах, дайвганах, дайвалзах, дайвах.

ТУЙВГАНУУЛАХ туйвганахын үйлдүүлэх хэв.

ТУЙЛ 1. мохоол, эцэс, хязгаар; *туйлдаа хүрэх; өвлийн туйл;* 2. маш, хамгийн; *туйлын муу; туйлын сайн; туйлын үнэн; туйлын хайрт;* 3. дэлхийн бөмбөрцгийн эргэх тэнхлэгийн хамгийн гадаад захын хоёр цэг ба мөн тэр орчны газар; *Өмнөд туйл; Умард туйл.*

ТУЙЛААДАС 1. түр зуур орох, бөөрөнхий ширхэгтэй хуурай цас; 2. туйлдас; *тэмээн туйлаадас; ингэн туйлаадас.*

ТУЙЛАХ 1. тэмээ, морь зэрэг малын булгих, бас ачаа, тэрэг зэргийг хөглөрүүлэн чирч давхих; *тэмээ туйлах; морин тэрэг туйлах; тэмээ туйлаад тэнгэрт хүрэхгүй, ямаа туйлаад янгирцаг эвдэхгүй* з ү й р; 2. ш и л ж э н дур мэдэн бужигнуулах; *хүний юманд орж орхиод харин нэг туйлж гарч байна даа!*

ТУЙЛГҮЙ хэмжээгүй, хязгааргүй; *туйлгүй их цас; туйлгүй их ус; туйлгүй дүрсгүй хүүхэд.*

ТУЙЛДАС туйлаадас.

ТУЙЛДАХ туйлдаа хүртэл зүдрэх, эцэх, ядрах; *би бүр туйлдах нь байна шүү гэж өвгөн хэлэв.*

ТУЙЛДУУЛАХ туйлдахын үйлдүүлэх хэв.

ТУЙЛУУЛАХ туйлахын үйлдүүлэх хэв.

ТУЙПУУ (Н) тоосго, зөн; *түүхий туйпуу; болсон туйпуу; туйпуу шатаах; туйпуун байшин:* **туйпууны завод** (туйпуу боловсруулан шатаах завод); **туйпууны хэв** (туйпууны хэмжээтэй модон хэв, дотор нь туйпуу үйлдэх шавар хийж шахна).

ТУЙТАЛЗАХ 1. хөлийн үзүүр гадагш хазгай явах, майжигнах, баацганан явах; 2. морь малын хойт хөл суунги, суусхийн явах.

ТУЙТАЛЗУУЛАХ туйталзахын үйлдүүлэх хэв.

ТУЙТГАНАХ туйтгар юмны үргэлжлэн хөдлөх.

ТУЙТГАР 1. хүний хөлийн үзүүр гадагш хазгай; 2. морь малын хойт хөл суунги; 3. майга, доголон.

ТУЙТРАХ 1. явахад хөл бохирох, нугачих; 2. хазганах.

ТУЛ I а м ь т а н цэнгэг усанд байдаг загас, нурууны этгээд харавтар улаан, өехийний этгээд цагаан, хайрс нарийн, шүдтэй, мах нь их амттай.

ТУЛ II учир, тиймийн учир; *миний юм мөн тул би авна; чи ирсэн тул би явлаа;* 2. төлөө; *чиний тул ийм хэрэг хийв; үнэн худлыг мэдэхийн тул.*

ТУЛААС тулсан, тогтоосон юм.

ТУЛАГДАХ тулахын үйлдэгдэх хэв.

ТУЛАЙ шээсэн хүчлийн давс хурсан шалтгаанаар үүсэх үе ба нэхмэлийн өвчин; *тулай гэм* ☆ **хэлэн тулай** (хэлгий чулчрай).

ТУЛАЙТАХ тулай гэм тусах.

ТУЛАЛДААН байлдаан, алалдаан, мөргөлдөөн, тэмцэлдээн; *тулалдааны талбар; тулалдаанд орох.*

ТУЛАЛДАХ тулахын үйлдэлдэх хэв; *алалдах тулалдах; хэрэлдэж тулалдах.*

ТУЛАЛДУУЛАХ тулалдахын үйлдүүлэх хэв, тулалдахад хүргүүлэх.

ТУЛАЛЦАХ тулахын үйлдэлцэх хэв.

ТУЛАМ 1. битүүгээр өвчиж шувтлан авсан арьс; *ямаан тулам; туламтай сүү;* 2. ш и л ж с э н ямар нэгэн муу сав мэт хүн; **хоолны тулам** (а. ажил үйл хийхгүй цалин авч суух; б. хоол идэхдээ ховдог шунахай); **мөнгөний тулам** (мөнгө идэгч, ашиглагч); **хэрүүлийн тулам** (хэрүүлч).

ТУЛАМЛАГДАХ туламлахын үйлдэгдэх хэв.

ТУЛАМЛАХ 1. амьтны арьсыг битүүгээр өвчих; *туламлаж өвчих;* 2. туламд хийх; *сүүгээ туламлах;* 3. ш и л ж с э н их идэх; *хоолоо туламлаж сууна уу.*

ТУЛАМЛУУЛАХ 1. туламлахын үйлдүүлэх хэв; 2 туламлагдах.

ТУЛАН: тулан загас а м ь т а н гарын алга шиг хавтгай биетэй, хайрсгүй, маш ширүүн арьстай загас, гарсыг сум шивэлдэхэд хэрэглэдэг.

ТУЛАР ухмал онгоцны ёроолын үзүүрийн газар.

ТУЛАХ 1. тулгуур болгох, түших, баганадах; *хазайсан хайсыг модоор тулав; баганаар тулах;* 2. тулгуур хийх; **түших тулах** х о р ш . : *эрүүгээ тулах; шанаагаа тулах; гараараа тулж босов; таяг тулах;* ☆ **ташаа тулах** (хэгжүүн, ихэмсэг зан гаргах); 3. юмны эцсийн цэгт хүрэх; *хувингийн ёроолд тулах;* 4. ш и л ж с э н хэтэрхий ойртож очих; *гэрт тулж очоод мориноос буув;* 5. бие биенд эрс шууд ойртон очих; *нүүр тулж уулзах;* 6. байлдах, дайтах; **байлдах тулах** х о р ш . ; 7. хэрэлдэх, тэмцэлдэх; *ам хэлээр тулах.*

ТУЛБАА тул загасны зулзага.

ТУЛБАР цоолтуур, төмөрлөгийг цоолох багаж.

ТУЛГА 1. ил задгай гал түлж дээр нь тогоо тавих хэрэгсэл; **зуух тулга** х о р ш . ; 2. юм тавих хөл, суурь.

ТУЛГАГДАХ тулгахын үйлдэгдэх хэв.

ТУЛГАМ аливаа хугацааны шахуу, богино; *их л тулгам хугацаагаар явах болов.*

ТУЛГАМДАХ сандрах, тэвдэх, тулгарах; *тулгамдаад хэлэх үгээ ч олохгүй байв; хугацаа тулгамдах.*

ТУЛГАМДУУЛАХ тулгамдахын үйлдүүлэх хэв, тулгаруулах; *явахыг эртхэн хэлэхгүй ингэж тулгамдуулах хэрэг юу байна даа?*

ТУЛГАР I 1. тугтам, шинэ; **тугтам тулгар, шинэ тулгар** х о р ш . ; *тулгар төр;* 2. анхны; *тулгар бичиг; тулгар баримт;* 3. жирэмсэн, бие давхар; *тулгар биетэй.*

ТУЛГАР II ичимхий, аймхай, хулчгар.

ТУЛГАРАЛТ тулгарах үйлийн нэр.

ТУЛГАРАХ 1. тулах, тулж очих, тулгардах; *тулж тулгарах; төлийг бүрэн бойжуулах чухал зорилт тулгарч байна; ойрдоо айраг ууганагүй тулгараад болохгүй байна;* 2. гэнэт дайралдах, мөргөлдөх; *тэнд бид хоёр яг тулгарав;* 3. үе дутуу мултрах; *хуруу нь тулгарчээ.*

ТУЛГАРДАХ 1. шинэдэх, дадлагагүйдэх, шинэдэж тэвдэх; *тулгардан ажилдаа самгар-*

даж байна; 2. эмээж бэрхшээх, сая нүүр учраад сандрах; *тулгардаад үг ярьж чадсангүй.*

ТУЛГАРДУУЛАХ тулгардахын үйлдүүлэх хэв, тулгаруулах.

ТУЛГАРИЛАХ барилдахад тэнцэн зай өгөхгүй байх.

ТУЛГАРУУЛАХ суурилах, тулгарахын үйлдүүлэх хэв.

ТУЛГАХ 1. тулахын үйлдүүлэх хэв; 2. хүлээлгэхээр шаардах, албадах; *хэргийг тулган хүлээлгэх; тулган тушаах; хөрөнгөтөн орон эрх тэгш биш гэрээг буурай орнуудад тулган хүлээлгэдэг;* **буу тулгах** (буудаж ална гэж буу гарган сүрдүүлэх); **тулган шаардах бичиг** (тухайн үйл хэрэгт татгалзвал даруй арга хэмжээ авахыг сануулж сүрдүүлсэн эрс шаардлага бүхий бичиг); 3. юмыг хооронд нь харшуулах, мөргөлдүүлэх; *хундага тулгах;* 4. шилжсэн хоёр юмыг хооронд нь шууд солих; *ганс эмээл хоёроо тулгаж орхиё гэв.*

ТУЛГУУЛАХ тулгахын үйлдүүлэх хэв.

ТУЛГУУР 1. тулах юм, багана; *модоор тулгуур хийх;* 2. онгоц сэлэх зэвсэг; **тулгуур онгоц** (тулгуурлан явах бага онгоц); 3. шилжсэн түшиг, хань, дэмжлэг; **түшиг тулгуур** хорш.; *гол тулгуур нь болох.*

ТУЛГУУР II тулгар.

ТУЛГУУРГҮЙ тулах юмгүй.

ТУЛГУУРДАХ 1. тулгуураар тулах; тулж тэгшлэх, тогтоох, баганадах; *хазайсан хашааг тулгуурдах;* 2. тулгуураар онгоц сэлэх.

ТУЛГУУРДУУЛАХ тулгуурдахын үйлдүүлэх хэв.

ТУЛГУУРИЛАХ 1. тулгуурдах; 2. түшиглэх, түшиж тулах; *түших тулгуурлах хүнтэй;* 3. шийдвэрлэх, эрс тэс тогтоох; *би тулгуурлан хэлж чадахгүй байна.*

ТУЛГУУРИЛУУЛАХ тулгуурлахын үйлдүүлэх хэв.

ТУЛГУУРЛАХ 1. тулгуурдах; 2. тулгарлах.

ТУЛГУУРЛУУЛАХ тулгуурлахын үйлдүүлэх хэв.

ТУЛГУУРТАЙ 1. тулгуур бүхий; 2. шилжсэн түшигтэй, дэмжлэгтэй; 3. шилжсэн ултай, нягт, хичээнгүй;.

ТУЛГУУРЬ түшиг, тулгуур, дэмжлэг, хамгаалал.

ТУЛГУУРЬТАЙ түшиг сайтай, дэмжлэг сайтай, хамгаалал сайтай; *цаанаа тулгуурьтай хүн.*

ТУЛД тул II.

ТУЛДУЙДАХ найдах, түшиглэх; *олны хүчинд тулдуйдах; авгын дэмжлэгт тулдуйдаж хүмүүжив.*

ТУЛУУЛАХ тулахын үйлдүүлэх хэв.

ТУЛХИ болхи, дорой хүн; ☆ **тулхи хутга** (мохоо хутга).

ТУМАРХАГ тумархах зантай, тунирхаг, тунирхуу.

ТУМАРХАХ тунирхах, тумархуу зан гаргах.

ТУМАРХУУ тумархаг, тунирхуу.

ТУМБАГАНАХ тумбагар юмны үргэлжлэн хөдлөх.

ТУМБАГАНУУЛАХ тумбаганахын үйлдүүлэх хэв.

ТУМБАГАР хүлхгэр, умбан, тумбан, цүлхгэр; *дундаа тумбагар арьс.*

ТУМБАЙЛГАХ тумбайхын үйлдүүлэх хэв.

ТУМБАЙХ 1. тумбагар болох; 2. шилжсэн дуугүй, амаа жимийж суух; *чи юунд тумбайж хоцроо вэ?*

ТУМБАЛАЙДАХ тумлайдах.

ТУМБАЛАЙДУУЛАХ 1. тумбалайдахын үйлдүүлэх хэв; 2. тумлайдуулах.

ТУМБАЛЗАХ тумбагар юмны байн байн хөдлөх.

ТУМБАЛЗУУЛАХ тумбалзахын үйлдүүлэх хэв.

ТУМБАН тумбагар.

ТУМЛАЙДАХ юмны нэг этгээдийг юмны доогуур шургуулж, нөгөө этгээдийг босгох бөгтрөх зэргээр хучих, тогтоох; *гэрийн хаяаг эсгийгээр тумлайдах; дээлээр хөлөө тумлайдаж хучих.*

ТУМЛАЙДУУЛАХ тумлайдахын үйлдүүлэх хэв.

ТУМЛАХ тунирхах, тумархах, айлгуур байдал гаргах; *айлгаж тумлах нь хялбархан хүн шүү; хүүхэд тумлах.*

ТУН I нэг удаагийн уух эмийн зохих хэмжээ; *зургаан тун халууны эм; хүүхдийн тун.*

ТУН II 1. тон, маш, туйлын, онц; *тун сайн; тун муу; тун хайртай; тун өшөөтэй;* 2. хэрхэвч; *тун болохгүй.*

ТУНААХ тунахын үйлдүүлэх хэв, тунахад хүргүүлэх.

ТУНАМАЛ гунасан юм; *тунамал ус; тунамал чулуулаг.*

ТУНАРАХ тунаж үлдэх, хоцрох; *оёдол нь тунарах.*

ТУНАРУУЛАХ тунарахын үйлдүүлэх хэв.

ТУНАХ 1. будингар юм өтгөн үе болж доош савын ёроолд буух; *цайны нитгэл тунажээ; усны булингар нь тунажээ;* 2. ш и л ж с э н юмны эцэст шигшигдэж үлдэх; *тунаж үлдсэн бөх;* 3. юмны тунаран хоцрох; *дээсний эрч тунах; дотор нь тунах.*

ТУНГААМАЛ тунгаасан зүйл; тунгаамал *алт; тунгаамал зэс.*

ТУНГААХ 1. тунахад хүргүүлэх; *усан дотор-хи шороо булингарыг тунгаах;* **алт тунгаах** (цэвэр алт гаргах); 2. ш и л ж с э н нарийвчлан нягталж хянах; *учры нь олж, хужры нь тунгаах.*

ТУНГАЛАГ 1. булингаргүй, гэрэл нэвт гарах, юм нэвт харагдах чанар; *шил шиг тунгалаг; тунгалаг ус; тунгалаг сар; тунгалаг огторгуй;* ☆ **тунгалаг жан** (шингэн жан); **тунгалаг цай** (дэвтээж идээшүүлсэн цай); **тунгалгийн судас** (цусан судал); 2. ш и л ж с э н саруул, сэргэлэн; **саруул тунгалаг, сэргэлэн тунгалаг** х о р ш.; *тунгалаг ухаан;* 3. ш и л ж с э н эрүүл амгалан; *бие лагшин тунгалаг уу? тунгалаг сайхан морилж байна уу?*

ТУНДАС I газар дээр бороо, цас болж буух агаарын нойт; *агаарын тундас.*

ТУНДАС II шингэн зүйлээс тунаж үлдсэн юм *дарсны тунадас.*

ТУНДР бөмбөрцгийн түйлын хавь орчин, тачир ургамалтай, намаг шалбааг бүхий газар; *тундрийн ургамал.*

ТУНЖРАХ багларах, өтгөн зузаан харагдах; *Туул голын бургас, тунжран хөхрөөд харагдана* (дуу); *үүл тунжрах.*

ТУНИМТГАЙ тунирхаг, тунимхай, үнэрхүү.

ТУНИМХАЙ тунирхаг, тунирхуу, тунимтгай.

ТУНИРХАГ тунимтгай, тунирхуу, туньж боодог; *тунирхаг хүн.*

ТУНИРХАХ туних, үнэрхэх, чадах атлаа гуйлгах.

ТУНИРХУУ тунирхаг, тунимтгай, тунимхай.

ТУНИХ үнэрхэх, эрхэмсэн чавхуурхах, чадах атлаа гуйлгах; *чи битгий туниад бай л даа.*

ТУНСАА борын хүчлийн услаг натри давснаас бүрэлдсэн цагаан саарал, шаравтар, ногоовтор өнгөтэй эрдэс, юм гагнахад хэрэглэнэ.

ТУНСААДАХ тунсаа түрхэх, тунсаа түрхэж гагнах.

ТУНТАЙЛГАХ тунтайхын үйлдүүлэх хэв, тунтайхад хүргүүлэх.

ТУНТАЙХ тунтгар болох, тумбайх; *цуваа толгой дээгүүрээ нөмрөөд галын хажууд тунтайгаад хэвтэв.*

ТУНТАЛЗАХ тунтгар юмны тумбалзан хөдлөх.

ТУНТАЛЗУУЛАХ тунталзахын үйлдүүлэх хэв.

ТУНТГАНАХ тунтгар юмны тумбага тумбага хөдлөх.

ТУНТГАР тумбагар, ёмбогор; *туламд хийсэн тунтгар юм.*

ТУНТРАХ 1. тумлайдах; *хааяа тунтрах; тунтарч хучих;* 2. хөрөнгө юм хураах; *хамаг малаа зарж мөнгө бараа болгон тунтарчихсан айл даа.*

ТУНТРУУЛАХ тунтрахын үйлдүүлэх хэв.

ТУНХАГ олон нийтэд ямар нэгэн зүйлийг танилцуулах уриалан зарлах бичиг; *ардын намын тунхаг; тунхаг бичиг.*

ТУНХАГЛАЛ тунхагласан нь; *тунхаглал гаргах.*

ТУНХАГЛАХ 1. тунхаг гаргах, зарлах, олонд мэдэгдэх; 2. хүн бүхэнд ярих, зар тараах; *зарлаж тунхаглаад явахын хэрэг юу байсан юм бэ!*

ТУНХАГЛУУЛАХ тунхаглахын үйлдүүлэх хэв.

ТУНХУУ I цай зэргийг хийх данх; *цайны тунхуу.*

ТУНХУУ II у р г а м а л иш моголцог болоод хөндий, навч хушуутай, цэцэг шар нэг зүйл ногоо.

ТУР I хот суурин газрын үлдэгдэл; *туйр сумийн тур; балгасны тур.*

ТУР II нарийн, уяхан; *энэ чинь тур муутайхан уурга байна даа.*

ТУРААЛ турахын туйл; *тураалдаа хүрч гүйцжээ.*

ТУРААХ турахын үйлдүүлэх хэв, турахад хүргүүлэх.

ТУРАГ амьтны том биетэй нь; *тураг мал;* **тураг шувуу** (том шувуу; *туурайт морь давхиж хүрэхгүй, тураг шувуу нисч хүрэхгүй* (үлгэр домгоос); **тураг загалмай** амьтан (начин харцгайн нам болох нэг зүйл шувуу, туулай зэргийг шааж барихдаа сурамгай); **тураг тас** амьтан (бүргэдийн нам, бие том, жигүүр сүүл бараан бөгөөд гялбалзам өнгөтэй шувуу, сумны зэрэг зэвсэг өдлөхөд өдий нь хэрэглэнэ); **тураг хэрээ** амьтан (хүзүү алаг, бие их нэг зүйл хэрээ); **тураг гөрөөс** (буга, согоо зэрэг махчин биш гөрөөс); **тураг солонго** амьтан (шар, цагаан алаг өнгөтэй, бяцхан солонго); **тураг сарааныи цэцэг** ургамал (цэцэг улаан өнгөтэй, иш навч цөм ногоон, хээр газар ургадаг нэг зүйл ургамал); **тураг мах** (амьтны их биеийн ба хар мах).

ТУРАНГИ туранхай, турхан.

ТУРАНГИДАХ мал, адгуус харшиж эцэх.

ТУРАНГИЛАХ турах, туранги болох.

ТУРАНГИЛУУЛАХ турангилахын үйлдүүлэх хэв, тураах.

ТУРАНХАЙ 1. эцэнхий; турхан; **эцэнхий туранхай** хорш.; *туранхай ямаа;* 2. амт шимгүй, өөх нүнжиг муу мах; *туранхай мах.*

ТУРАНХАЙДАХ хэтэрхий туранхай болох.

ТУРАНХАЙДУУЛАХ туранхайдахын үйлдүүлэх хэв.

ТУРАХ туранхай, эцэнхий болох, турхан болох; **эцэх турах** хорш.; *хавар ихээхэн турсан мал; турж үхэх.*

ТУРБИН хоолой.

ТУРГИХ 1. морь малын хамраа турдхийж дуугаргах; *морь тургих; ямаа тургих;* 2. хүний үлээж уруулаа доргилуулан дуугарах; *битгий тургиарай; дээш нь тургиж болохгүй, тэнгэр задарна;* 3. амаар ус балгаж юманд үлээж сүрших; *ус тургиж шүүрдвэл тоос бургих нь бага байдаг.*

ТУРГУН дутуу, цөөн хүрэлцээгүй; дутуу **тургун** хорш.;

ТУРЛААХЬ турлиах.

ТУРЛИАХ амьтан хэрээний төрлийн хар саарал буюу хар өнгөтэй, юм бүхэн идэх шувуу,.

ТУРСАГА турж үхсэн хонь, ямааны арьс.

ТУРУУ туур, туурай.

ТУРУУТ туруу бүхий, туурайт.

ТУРУУТАН туруу бүхий амьтан, туурайтан; *ац туруутан; салаа туруутан.*

ТУРХАН туранхай, эцэнхий

ТУРХАНДАХ хэтэрхий турхан болох, туранхайдах.

ТУРХАНДУУЛАХ турхандахын үйлдүүлэх хэв.

ТУРШ 1. бүх дагуу, туж; *замын хажуу туршид нь мод тарьж байна;* 2. дуусан; *өдөр турш ном уншив; жилийн турш хөдөө явав.*

ТУРШИГДАХ туршихын үйлдэгдэх хэв.

ТУРШИЛ турших үйлийн нэр; *туршил хийх.*

ТУРШИЛТ турших үйлийн нэр; *цөмийн зэвсгийн туршилтыг зогсоох.*

ТУРШИХ 1. сорих; **тэнсэх турших** хорш.; *битүү турших; туршиж асуух; үнэндээ чингээгүй, би чамайг зөвхөн яадаг юм бол гээж туршсан юм;* 2. туршлага хийх; *шинэ загварын машин турших; цөмийн зэвсэг туршиж явдлыг хориглох; нисэх онгоц турших;* 3. тэнсэх; *чадах эсэхээ мэдэхгүй байна, туршаад үзье л дээ.*

ТУРШЛАГА 1. ажиллаж олсон бүх мэдэц, чадвар; *туршлага солилцох;* 2. заншил, хэвшил; *чингэсээр ирсэн туршлагатай;* 3. шинжлэх судлах зорилгоор ямар нэг үзэгдэл юмыг турших нь; *физиологийн хичээл дээр нохойгоор туршлага хийж үзүүлэв;* **туршлага хийх** (болох эсэхийг сорьж, тэнсэн үзэх); **химийн туршлага** (бодисыг задлах, нийлүүлэх); **туршлага станц** (тариа ногоо зэргийг туршиж ургуулах газар).

ТУРШЛАГАГҮЙ туршлага дадлага байхгүй.

ТУРШЛАГАЖИХ туршлагатай болох, туршлага суух.

ТУРШЛАГАЖУУЛАХ туршлагажихын үйлдүүлэх хэв.

ТУРШЛАГАТАЙ хашир, догь, урьд үзсэн, мэдсэн нь их; *туршлагатай анчин; туршлагатай ажилчин.*

ТУРШЛАГАШИХ туршлага олох, туршлага суух.

ТУРШУУЛ турших үйлийн нэр; туршигч; **тагнуул туршуул** х о р ш . ; *туршуул хийх.*

ТУРШУУЛАХ 1. туршихын үйлдүүлэх хэв; 2. туршигдах.

ТУРШУУЛЧ туршуул хийх хүн.

ТУС I нэмэр, ашиг, ач; **нэмэр тус, ашиг тус, ач тус** х о р ш.; *тусыг усаар з ү й р; тус үзүүлэх; хувийн ашиг тусыг хамгаалах;* **тусад орох** (хүүхэд, ойр зуурын ажил хийж сурах).

ТУС II орчим; *толгойн тус газар; мөрний тус газар дайрагдав.*

ТУС III энэ, мөн, тусбүр, өөр өөрийн; **тус тус** х о р ш.; *тус улсын харьяат; тус орны хөгжлийн түүх; тус тусынхаа үүрэгт ажилд хариуцлагатай байх хэрэгтэй.*

ТУСААХ тусахын үйлдүүлэх хэв, **тусахад хүрүүлэх.**

ТУСАМ I тутам, улам бүр; *хэлэх тусам дордов; унасан морь минь явах тусам хөл нь хөнгөн болж байв.*

ТУСАМ II хүрч тусах, тусч чадахуйц; *сум тусам газар.*

ТУСАМТГАЙ тусахдаа хялбар; *өвчин тусамтгай хүн.*

ТУСАХ 1. онох, тохиолдох; *сум тусах; шидсэн чулуу яг хөлийн шагаа дээр нь тусчээ;* 2. гэрэл, сацраг, сүүдэр зэргийн дайрах, буух; *гэрэл тусах;* **нар тусах** (нар дайрах); **сүүдэр тусах** (сүүдэр дайрах); 3. юмны дүрс ус, шил зэрэг гилгэр юманд харагдах; *толинд тусах; биеийн дүрс усанд тусах;* 4. ш и л ж с э н нүдний харц тохиох; *нүд нь миний тамхины саван дээр тусч байв;* 5. юмны хүчинд эрс гэмтэх; **хага тусах** (хагарах); **хуга тусах** (хугарах); **цоо тусах** (цоорох); ☆ **зог тусах** (гэнэт зогсох, сочмог зогсох; *буурал морь минь гэнэт зог тусав.*

ТУСБҮР тус тус, нэгбүр, тутам; *хүн тусбүрийн үнэмлэхийг шалгаж үзэв; тусбүр арваад бухал өвс хаджээ.*

ТУСГААР 1. дангаар, тусдаа; *тусгаар явах;* 2. биеэ даасан, бусдын харгалзлагагүй, хараат биш; *тусгаар улс болох; тусгаар тогтнох; Бүгд Найрамдах Монгол Ард Улс бол тусгаар тогтносон улс мөн.*

ТУСГААРЛАГДАХ тусгаарлахын үйлдэгдэх хэв.

ТУСГААРЛАГДМАЛ тусгаарлагдсан шинж байдалтай.

ТУСГААРЛАГЧ тусгаарлах үйлийн нэр; *цахилгаан тусгаарлагч.*

ТУСГААРЛАХ тусгай болгох, тусгайлах, хамт үл байлгах; *халдварт өвчтэй малыг тусгаарлах; ам данс тусгаарлах.*

ТУСГААРЛУУЛАХ 1. тусгаарлахын үйлдүүлэх хэв; 2. тусгаарлагдах.

ТУСГААРЛУУР тусгаарлах хэрэгсэл; **цахилгааны тусгаарлуур** (цахилгаан гүйдлийг үл нэвтрүүлэх зүйлс).

ТУСГАГЧ тусгадаг юм.

ТУСГАЙ 1. тусдаа, өөр, анги; *ам өрх тусгай; тусгай байлгах; тусгай цаг гаргах; тусгай тусгай бүлэг болгож зохиох;* 2. онцгой; *тусгай шалтгаан; хуулийн тусгай анги;* 3. жич, ангид; *энэ тухай тусгай ярилцах болно;* ☆ **тусгай мэрэгжил** (шинжлэх ухаан, техник, урлагийн алив нэг салбар; *дунд сургууль төгсөөд хэл бичгийн тусгай мэрэгжил сонгож авав*); **тусгай мэрэгжлийн сургууль** (оноосон мэрэгжилд сургах дунд боловсролын сургууль).

ТУСГАЙЛАГДАХ тусгайлахын үйлдэгдэх хэв.

ТУСГАЙЛАХ 1. тусгай болгох, тусад нь болгох, тусгаарлах; 2. онц болгох, онцгойлох; тусгайлж үзэх; *тусгайлан орон байр гаргаж байлгав; тусгай элч зарж...*

ТУСГАЙЛУУЛАХ 1. тусгайлахын үйлдүүлэх хэв; 2. тусгайлагдах.

ТУСГАЙРАХ тусгай болох, тусдаа болох; *тусгайран салах.*

ТУСГАЙРУУЛАХ тусгайрахын үйлдүүлэх хэв.

ТУСГАЛ тусгах үйлийн нэр; *тусгал сайтай; тусгал муутай; том толинд туссан өөрийн тусгалыг би үзээд өөр хүн байна гэж эндүүрэв.*

ТУСГАХ тусахын үйлдүүлэх хэв, тусахад хүрүүлэх.

ТУСГҮЙ 1. ашиг, нэмэргүй; *өнөөдөр яваад тусгүй, чи маргааш яв;* 2. дэмий, муу; *тусгүй явдал; тусгүй хүн.*

ТУСЛАГЧ 1. бусад хүний үйл ажилд туслан үйлчлэгч хүн; *даргын туслагч; эрдэмтний туслагч;* 2. х у у ч и р с а н хушууны тамгын түшмэлийн ахлах туслах; *тамгын туслагч; хушуу туслагч.*

ТУСЛАМЖ тэтгэмж, нэмэр, дэмжлэг; *тусламж гуйх; Зөвлөлтийн сэтгэл харамгүй тусламжаар манай улс хөгжиж байна;* **тусламж үзүүлэх** (туслах); **тусламж авах** (туслуулах); ☆ **түргэн тусламж** (гэнэтийн өвчин, осол зэрэгт даруйхан эмнэлгийн туслалцаа үзүүлэх байгууллага).

ТУСЛАМЖЛАХ тусламж үзүүлэх.

ТУСЛАМЖЛУУЛАХ тусламжлахын үйлдүүлэх хэв.

ТУСЛАХ 1. тус хийх, тус болох; *ажилд нь туслах; чамд би тусалъя;* 2. сайн дураар юм өгөх, нэмэр хандив болгох; *хашаа саравчаа нэгдэлд туслав;* 3. туслагч; *миний туслахаар гарын үсэг зуруулаарай;* **туслах чанарын аж ахуй** (дагалдах, хоёрдугаар зэргийн аж ахуй); **туслах үйл үг** (нийлмэл өгүүлэхүүний бүрэлдэхүүнд орж тухайн үйл буюу байдлын чухам хэзээ болсон, болж байгаа, болсон цагийг заах үйл үг).

ТУСЛУУЛАХ туслахын үйлдүүлэх хэв.

ТУСТАЙ тус бүхий; *улс нийгэмд тустай ажил; эрдэм сурвал биенд тустай, улсдаа ч тустай.*

ТУТАМ бүр, нэгбүрд; *хүн тутам; өдөр тутам; сар тутам нэг удаа гарах сэтгүүл.*

ТУТРАГА цагаан будаа.

ТУСТУС 1. тусбүр, нэгбүр, тутам; *тустусын өргөдлийг гаргаж иржээ; тустусын унасан морийг идүүлж хонов;* 2. өөр өөр, тусгай тусгай, анги анги; *тустус оршин сууна.*

ТУУ I нохой зэргийг тухирах аялгуу.

ТУУ II а м ь т а н хүзүү алаг, хэрээнээс бага, хавар намар сүрэглэн явдаг шувуу; алаг туу ч гэнэ.

ТУУВАР туух үйл явдлын нэр; *тууврын мал; тууврын зам.*

ТУУВАРДАХ тууврын замд туугдаж яваа мал сүргийн зүдэж ядах.

ТУУВАРДУУЛАХ туувардахын үйлдүүлэх хэв.

ТУУВАРЛАХ мал сүргийг замд туух; *мал тууварлах ажил.*

ТУУВАРЛУУЛАХ тууварлахын үйлдүүлэх хэв.

ТУУВАРШИХ туувардах, туувартаа ядрах.

ТУУВАРШУУЛАХ тууваршихын үйлдүүлэх хэв.

ТУУГДАХ туухын үйлдэгдэх хэв.

ТУУГЧИД мал туудаг хүмүүс; *мал тууг-чдын тэргүүний туршлагыг дэлгэрүүлэх.*

ТУУЖ 1. хүүрнэн өгүүлэх уран зохиолын нэгэн зүйл, хэмжээ болон үйл явдлын хувьд романаас бага байна; *тууж бичих;* 2. х у у ч и р с а н түүх; *Чойжид дагинийн тууж.*

ТУУЖУУ хог саг арилгах шүүр; *хялгасан туужуу; өвсөн туужуу.*

ТУУЖУУДАХ 1. туужуугаар арчих, цэвэрлэх; 2. туужуугаар цохих, жанчих.

ТУУЖУУДУУЛАХ туужуудахын үйлдүүлэх хэв.

ТУУЗ юм эмжих, хөвөөлөх, чимэглэхэд хэрэглэх тусгай нарийн зурвас эд; *эрээн тууз; цулгуй тууз; саатай тууз.*

ТУУЛАЙ а м ь т а н мэрэгчийн нам, чих урт, хойт хөл өндөр, сүүл богино болоод ээтгэр, бие жижиг, төрөл олон, дэлхий дээр түгээмэл амьтан; *туулайн арьс; туулайн хирээр нумаа тат, тугалын хирээр зэлээ тат* з ү й р; **молтогчин туулай** а м ь т а н (нэг төрлийн туулай); **туулай жил** (Дорно зүгийн зурхайн ёсны арван хоёр жилийн дөрөвдүгээр туулай эзэлсэн жил); **туулайн бөөр** у р г а м а л (хальс нимгэн бөгөөд улаавтархан, цөм шар, хальсыг хуулж иддэг нэгэн зүйл жимс); **туулайн тагнай** у р г а м а л (саргай цэцгийн язгуурт багтах, олон наст өвслөг ургамал, цагаан шаравтар цэцэгтэй, цэцгийн дэлбэ цоморлог нь 5—6 хэлтэстэй, эмнэлэгт хэрэглэнэ).

ТУУЛАХ 1. ус мөрнийг гэтлэх, гатлах, гарах; *ус туулах; шалбааг туулах;* 2. зовлон зүдгүүр, бэрхшээл өнгөрөөх; *хүнд бэрхшээлийг даван туулсаар ирэв; цас зудын аюулыг даван туулж мал онд мэнд оров.*

ТУУЛАХ II 1. юмыг дайрч нэвтрэн өнгөрөх; *өргөн фронтыг туулах; алсын аяны их замыг хөтлөгөө марь туулав;* 2. алив үйл хэргийг нэвтэрхий мэдэх.

ТУУЛАХ III хүний биед эсэргэнэ гүвдрүү гарч туурах; *улаан эсэргэнэ туулах.*

ТУУЛАХ IV суулгах; чацга алдах.

ТУУЛГА ууж доош суулгах эмийн зүйл; *давсан туулга; тосон туулга.*

ТУУЛГАХ I эм ууж уруу суулгах.

ТУУЛГАХ II туухын үйлдүүлэх хэв; 2. тууг-дах.

ТУУЛИХ дайн байлдааны газарт уулгалан олз авах.

ТУУЛУУЛАХ туулахын үйлдүүлэх хэв.

ТУУЛЬ ардын аман зохиолын шүлэглэн хэлэх томоохон төрөл зүйл; **үлгэр тууль** х о р ш..

ТУУЛЬЧ тууль ихэд мэдэж ярьдаг хүн.

ТУУПЛАН нэгэн зүйл ургамлын үндэс эмнэлэгт хэрэглэнэ.

ТУУР I у р г а м а л 1. янз бөөрөнхий, үзүүр баахан хэлбэгий, амт амтайхан нэгэн зүйл жимс; 2. мөн жимс ургах мод, цэцэг улаан.

ТУУР II аливаа мал, гөрөөсний элгэнд хадаж ургасан нимгэн мах.

ТУУРАЙ зарим адгуусан амьтны хөлийн үзүүрт байдаг эвэрлэг зүйл; *цомбон туурай; хомбон туурай.*

ТУУРАЙТ туурай бүхий, туруут.

ТУУРАЙТАН туурай бүхий амьтад, туруутан; **битүү туурайтан** (ац туурайтны аймагт үл багтах битүү туурайтай амьтад); **ац туурайтан** (сүүгээр бойжигчдын багийн ац туурайтай амьтад).

ТУУРВИЛ үйл ажлын эхлэл, төсөв мөн ажил хэргийн шийдвэр, дуусвар; *их туурвил.*

ТУУРВИХ үйл явдлыг төсөвлөн тогтоох, барагдуулан дуусгах; *ном туурвиж эхэлсэн бидээ.*

ТУУРГА 1. байшин барилгын хажуу этгээдийн хана; *байшингийн туурга;* 2. гэр, асар, цацрын хажуу этгээдэд нөмөргөн бүтээх эсгий бөс; *эсгий туурга; брезент туурга.*

ТУУРГАТАН үндэстэн, хэлтэн; *монгол туургатан.*

ТУУРТ туурай бүхий, туруут.

ТУУРТАН туурайтан.

ТУУРЬ хүний гэрийн үеийн бичмэл цэдэг.

ТУУС 1. шууд, чигээрээ; *туус зам;* **туус явах** (сааталгүй алс явах); 2. дагуу, турш, шулуун; *туус мод; туус ширээ.*

ТУУСЛАХ туус болгох.

ТУУСРАХ туус болох.

ТУУХ амьтныг алгуурхнаар хойноос нь үлдэн хөөх; **хөөх туух** х о р ш . .

ТУУХАЙ жигнүүр цэгнүүрийн үзүүрт өлгөх буюу нэгэн этгээдэд тэнцүүлэн тавьж хэмжих хэмжээтэй төмөрлөгийн зүйл.

ТУУХАЙ II шагааны морин этгээд; ☆ **туухай зангидах** (нэгэн зүйл зангилаа).

ТУУХАЙЦАХ шагаа орхин алцуу туухайг үзэж наадах.

ТУУХАЙЦУУЛАХ туухайцахын үйлдүүлэх хэв.

ТУУШ 1 .эгц, шулуун, хөндлөн биш, дагуу; *тууш урт мод; тууш ширхгийн дагуу;* 2. турш; *өдөр тууш чи хаагуур явдаг хүн бэ?*

ТУУШГҮЙ шийдгүй, шийдвэргүй, зориг муутай.

ТУУШРАХ шулуудах, цэгцрэх; *ажил чинь нэгэнт тууширсан хойно, явахад бэлэн биз ээ.*

ТУУШТАЙ шийдтэй, шийдвэртэй, зориг сайтай; *тууштай уг хэлэх.*

ТУХ яаралгүй, тайван байх байдал; тав тух х о р ш . ; *тухтай суух; тух алдах.*

ТУХАЙ 1. төлөө; *ялалтын тухай; аз жаргалын тухай;* 2. хэргээр; *та ямар тухай ирэв? энэ тухай дуугүй байж болохгүй;* 3. учир холбогдол; *бид шинэ номын тухай ярилцаж суна;* 4. тус тус; *тухай тухай авч үзэх хэрэгтэй юм;* 5. цаг үе *тухайн байдлыг харан байж болъё; тухай бүрд нь бодож шийдвэрлэх хэрэгтэй юм; цаг тухайд нь арга хэмжээ авах хэрэгтэй,* 6. хувьд; *энэ хэргийн тухайд гэвэл; миний тухайд юу гэж үзэх вэ?*

ТУХАЙЛАГДАХ тухайлахын үйлдэгдэх хэв.

ТУХАЙЛАХ 1. үйл явдлын дотроос нэгийг онцлж тусгайлан үзэх; *тухайлж хэлбэл тэр болохгүй хэрэг мөн;* 2. таах, барагцаалах, тоймлох; *тухайлж бодоход; тухайлж байна; тухайлж сууна;* 3. чухам хаанахын; *та тухайлбал хэнийх вэ? нэр алдар хэн гэдэг вэ?*

ТУХАЙЛУУЛАХ 1. тухайлахын үйлдүүлэх хэв; 2. тухайлагдах.

ТУХАЙТАЙ ойролцоо; төсөөтэй; *нилээд тухайтай байна.*

ТУХГҮЙ тавгүй, тайвангүй, тохигүй.

ТУХГҮЙДЭХ тохигүйдэх, тавгүйдэх.

ТУХГҮЙХЭН арай тухгүй, нилээд тухгүй, тавгүйхэн, тохигүйхэн.

ТУХИРАГДАХ тухирахын үйлдэгдэх хэв.

ТУХИРАГЧ тухирах зантай этгээд.

ТУХИРАХ 1. нохой зэргийн амьтныг буслыг айлгах ба хорлуулахаар дохиолох; *нохой тухирах;* 2. хүнийг муутгах буюу хөнөөтүгэй гэж хатган өрнүүлэх; *битүүгээр тухираад биеэ нууж байгаа биз ээ.*

ТУРХИРЛАГА тухирах үйлийн нэр.

ТУХИРУУЛАХ 1. тухирахын үйлдүүлэх хэв; 2. тухирагдах.

ТУХЛАГДАХ тухлахын үйлдүүлэх хэв.

ТУХЛАХ хүний үйл ажилд яаралгүй тавтай байх; тавлах; **тавлах тулах** х о р ш..

ТУХЛУУЛАХ 1. тухлахын үйлдүүлэх хэв; 2. тухлагдах; *би тэднийд очоод тухлуулж тухлуулж ирэв.*

ТУХТАЙ тавтай, тайван аятай; *тухтай ажиллах хэрэгтэй байна.*

ТУШАА I 1. малын хөлийг холбож торгох оосор; *унээний тушаа; хялгасан тушаа; морины тушаа; төмөр тушаа;* 2. тэмээний шатын хойт урьд хоёрыг холбож торгох эрээс ба шатны эмээлийг шатанд нь холбож торгосон холбоос; *шатны тушаа;* 3. барилга савын яс мод зэргийг холбосон зүйл; *байшингийн тушаа мод; тушаа нуруу; ширээний тушаа;* 4. ш и л ж с э н саад тотгор; *чи битгий тушаа болоод бай! би түүний чинь хийх гээд байгаа юм; тус болох гээд тушаа болох з ү й р.*

ТУШАА II 1. хавь, орчин; *энэ тушаа байсан; үүдэн тушаа харагдсан байх;* 2. тус тус; *тушаа тушаа явцгааж байтал ...* 3. орчим; *хорин тав тушаа; зургаан цаг тушаа.*

ТУШААГДАХ тушаахын үйлдэгдэх хэв.

ТУШААЛ 1. албаар тогтоож заасан заавар, шийдвэр; *заавар тушаал; тогтоол тушаал;* 2. албаны хүний эрх үүрэг; *албан тушаал; бичиг хэргийн эрхлэгчийн тушаал; тушаал хүлээх; тушаалаас буулгах.*

ТУШААЛГАХ тушаахын үйлдүүлэх хэв, тушаахад хүргүүлэх.

ТУШААЛДАХ тохиолдох, дайралдах.

ТУШААЛДУУЛАХ тушаалдахын үйлдүүлэх хэв, тохиолдуулах.

ТУШААЛТ I зэрэг дэс албан тушаал бүхий.

ТУШААЛТ II тушаах үйлийн явц; *мал тушаалт; ноос тушаалт.*

ТУШААЛТАЙ тушаал бүхий.

ТУШААЛТАН тушаал бүхий хүмүүс; *албан тушаалтан; дээд тушаалтан.*

ТУШААХ I албадан тулгах; *дээрээс тушаах; ажилд томилох тухай тушаах нь ...*

ТУШААХ II улс ба албан газарт нийлүүлэх өгөх; *кассад мөнгө тушаах; улсын орлогод мөнгө тушаах; албан журамд мах тушаах.*

ТУШИМ хуягт хадах төмөр навч.

ТУШИХ тушаагаар торгох, бэхлэх; *үнээ туших; морь туших.*

ТУШУУЛАХ тушихын үйлдүүлэх хэв.

ТУЯА ямар нэгэн гэрэл бүхий юмнаас дам гарсан буюу ойж гарсан тод зурвас гэрэл; *нарны туяа; толины туяа; галын туяа; туйлын туяа.*

ТУЯАЛАХ туяа гарах; *нар туяалах.*

ТУЯАЛУУЛАХ туяалахын үйлдүүлэх хэв.

ТУЯАРАХ туяа гарах, туяа татаж харагдах; *солонго туяаран харагдаж байна; улаан гэрэл туяарч байна.*

ТУЯАРУУЛАХ туяарахын үйлдүүлэх хэв.

ТУЯАТ туяа бий.

ТУЯАТАЙ туяа бүхий.

ТУЯГАНАХ туягар юмны хөдлөх байдал.

ТУЯГАР турь муутай, уяхан, нарийн.

ТУЯЛАХ агаарт улаан үүл тархагдах.

ТУЯЛИГ: туялиг мод у р г а м а л иш улаан, навч ногоон; цэцэг харавтар улаан нэгэн

зүйл мод, халуун оронд ургана; **туялиг цэцэг** ургамал (навч урт шовхгор, цэцэг нь таван хэлтэстэй бөгөөд туялсан үүлний адил өтгөн хүрэн өнгөтэй нэгэн зүйл цэцэг).

ТУЯХАН 1. уяхан: **уяхан туяхан** хорш.; 2. тур муутай, нарийн; *туяхан хүн; туяхан уурга.*

ТУЯХАНДАХ хэтэрхий туяхан болох.

ТҮВДҮҮЛЭХ 1. түвдэхийн үйлдүүлэх хэв; 2. тэвдүүлэх, давчдуулах.

ТҮВДҮҮРГҮЙ тавтиргүй, тэвчээргүй.

ТҮВДҮҮРТЭЙ төв оршингүй байдалтай, тэвчээртэй.

ТҮВДЭХ 1. тэвчих, санаа сэтгэлээ барьж чадах; *хүлцэн түвдэх; цээрлэн түвдэх;* 2. саная бодлоо тэвчиж муу хэрэг үл үйлдэх; *авдэж түвдэх; амийг таслан түвдэх.*

ТҮВДЭШГҮЙ түвдэх арга нөхцөлгүй, тэвчишгүй.

ТҮВШГҮЙ тайвангүй, уур хилэнтэй.

ТҮВШДҮҮЛЭХ түвшдэхийн үйлдүүлэх хэв.

ТҮВШДЭХ хэтэрхий түвшин болох, түвшний учир тохиромжгүй болох.

ТҮВШИН 1. энх, тогтниун, аятай; **энх түвшин, түвшин тогтниун** хорш.; *түвшин цаг; түвшин өдөр;* 2. хазгай гажуугүй, тэгш; *түвшин ширээ түвшин суух; түвшин газар;* 3. үйл явдалд дутагдал, гачигдал, тэрслүү буруугүй, тайван; **түвшин тайван** хорш.; *түвшин зан; төр түвшин;* 4. төлөв; **төлөв түвшин** хорш.; *түвшин хүн;* **далайн түвшин** (дэлхийн гадаргуу дахь өндөрлөгүүдийг хэмжих тогтоосон цэг).

ТҮВШИТГҮҮЛЭХ түвшитгэхийн үйлдүүлэх хэв.

ТҮВШИТГЭХ түвшдэхийн үйлдүүлэх хэв, түвшин болгох, амгалан тайван болгох; *барууын хязгаарыг түвшитгэх.*

ТҮВШЛҮҮЛЭХ 1. түвшлэхийн үйлдүүлэх хэв; 2. түвшлэгдэх.

ТҮВШЛЭГДЭХ түвшлэхийн үйлдэгдэх хэв.

ТҮВШЛЭХ түвшин болгох.

ТҮВШРҮҮЛЭХ түвшрэхийн үйлдүүлэх хэв.

ТҮВШРЭХ түвшдэх, түвшин болох.

ТҮВШТЭХ 1. юм улмаар түвшин болох; 2. амгалан тайван болох; *цаг төр түвштэх.*

ТҮВШҮҮР 1. байнга, тогтмол, 2. амгалан тайван.

ТҮВШҮҮРГҮЙ 1. байнга, тогтмол биш; 2. амгалан тайван биш.

ТҮВШҮҮРТЭЙ түвшүүр бүхий, түгшүүртэй.

ТҮВШЭЭРЭХ хүний явдал байдал төв оршингүй болох.

ТҮВЭГ ажиллагаа ихтэй; **ярших түвэг** хорш.; *түвэг болох; түвгийг барах; түвэг багатай.*

ТҮВЭГГҮЙ юм хийхэд яршиг ярвиг бага хялбар; *түвэггүй ажил; түвэггүй хоол хийгээд идье.*

ТҮВЭГЛҮҮЛЭХ түвэглэхийн үйлдүүлэх хэв.

ТҮВЭГЛЭХ түвэг гаргах, түвэг болох.

ТҮВЭГТҮҮЛЭХ түвэгтэхийн үйлдүүлэх хэв.

ТҮВЭГТЭЙ түвэг бүхий; түвэг ихтэй; *түвэгтэй хүн; түвэгтэй хэрэг; түвэгтэй ажил.*

ТҮВЭГТЭХ түвэг удах, түвэг гаргах.

ТҮВЭГШИЛ яршиг түвэг их; *түвэгшил бага гаргах; түвэгшил учрах.*

ТҮВЭГШИЛГҮЙ яршиг бэрхшээл багатай, ажиллагаа багатай.

ТҮВЭГШИЛТЭЙ яршиг түвэгшил ихтэй, бэрхшээлтэй, ажиллагаа ихтэй.

ТҮВЭГШЭЭЛ түвэгшээх үйлийн нэр, бэрхшээл.

ТҮВЭГШЭЭНГЭ түвэгшээсэн үзэгдэл байдал, бэрхшээх байдал.

ТҮВЭГШЭЭХ хийх бүтээхэд түвэгтэй гэж бэрхшээх, халшрах, түвэгтэйд үзэх; *биеийн хөдөлмөр хийхээс түвэгшээх хүн гэж байх уу?*

ТҮГ I: түг түм 1. түмэн түмэн; 2. маш олон, үй түм; *талбайд түг түмэн хүн жагсаж байна.*

ТҮГ II: **түг түг хийх түг таг хийх** нэгэн зүйл чимээ; *зүрх түг түг цохилох; энэ түг таг хийдэг ямар юмны чимээ вэ?*

ТҮГДГЭР бөгтгөр, бөхгөр байдалтай юм; *энэ яасан түгдгэр нуруутай хүн бэ.*

ТҮГДИЙЛГЭХ түгдийхийн үйлдүүлэх хэв, түгдгэр болгох.

ТҮГДИЙХ түгдгэр болох; *түгдийгээд сууж байна.*

ТҮГДРҮҮЛЭХ түгдрэхийн үйлдүүлэх хэв.

ТҮГДРЭХ I үг ярих хэлэхдээ торж зогсголзох; *бичсэнийг хараад үншихдаа түгдрээд байх юм.*

ТҮГДРЭХ II хугалах, хагалах, хэмхлэх, эмтрэх.

ТҮГДЧИХ I байн байн түгдрэх.

ТҮГДЧИХ II эвдчих, хагачих, хэмхчих, эмтчих.

ТҮГДЧҮҮЛЭХ түгдчихийн үйлдүүлэх хэв.

ТҮГДЭГНЭХ түгдгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ТҮГДЭЛЗЭХ түгдгэр юмны байн байн хөдлөх.

ТҮГДЭРХИЙ I 1. хугарах, хагарахдаа хялбар; 2. хагархай, хугархай, хэмхэрхий, эмтэрхий.

ТҮГДЭРХИЙ II зөв бурууг ялгахгүй даруй хилэгнэж уурладаг хүн.

ТҮГЖГЭР эвэргүй мухар; *түгжгэр бяруу.*

ТҮГЖИГДМЭЛ түгжигдсэн юм; *түгжигдмэл байдалтай.*

ТҮГЖИГДЭХ түгжихийн үйлдэгдэх хэв.

ТҮГЖИЙХ түгжгэр болох.

ТҮГЖИХ юмыг ягштал битүүмжлэн хаах; *хаалга түгжих; үүд түгжих; нүх түгжих.*

ТҮГЖРҮҮЛЭХ түгжрэхийн үйлдүүлэх хэв.

ТҮГЖРЭХ битүүрэх, бөглөрөх; *гансны мод түгжрэх; хамар түгжрэх.*

ТҮГЖҮҮЛЭХ түгжихийн үйлдүүлэх хэв.

ТҮГЖЭЭ юмыг түгжих бэхлэх оньс, хөндлөн даруулга, мод төмөр зэрэг юм; түгжээс; *хаалганы түгжээ; үүдний түгжээ; ширээний түгжээ.*

ТҮГЖЭЭС түгжээ.

ТҮГМЭЛ юмны нийтэд тархаж хүрэлцсэн, нь, тархмал, тармал, түгээмэл.

ТҮГСҮҮР юмыг жанчих томоохон модон алх; *тарианы түгсүүр; газрын түгсүүр.*

ТҮГСЭХ юмыг түгсүүрээр цохих; *тариа түгсэх; төмөр түгсэх; газар түгсэх; самар түгсэх.*

ТҮГШИЛГЭ сэтгэлд айх газар бий бөгөөд сэтгэл санаа амаргүй.

ТҮГШИХ 1. зүрх булгилах, сандран айх; *зүрх түгших; дотор түгших;* 2. морь малын зовол хэтэрч цавины тус дэлсэх; *миний морь түгшив.*

ТҮГШЛЭГ түгших үйлийн нэр.

ТҮГШМЭЛ түгшсэн юм.

ТҮГШҮҮЛЭХ түгшихийн үйлдүүлэх хэв.

ТҮГШҮҮР I мал гөрөөсний элэгний тус цоройны гол дахь бяцхан мах.

ТҮГШҮҮР II 1. айх зүйл бүхий учир сэтгэлийн зовол; 2. аюул тулгарсныг мэдэгдэх дохио; *түгшүүр зарлах; түгшүүр өгөх.*

ТҮГШҮҮРГҮЙ түгших, айх зовох зүйлгүй.

ТҮГШҮҮРТЭЙ аймшигтай, зовуурьтай эмээлгэй; *түгшүүртэй цаг; түгшүүртэй байдал; түгшүүртэй үеийн амьдрал.*

ТҮГЭХ юмны дэлгэрэнгүй болох ба олонд нийгэн тарах; *олонд зар түгэх; өвчин түгэх;* **од түгэх** (харанхуй болж од үлэмжхэн үзэгдэх).

ТҮГЭЭГҮҮР түгээдэг юм; *ус түгээгүүр.*

ТҮГЭЭГЧ түгээх үйлийг гүйцэтгэгч; *цэргэг түгээгч байсан.*

ТҮГЭЭЛ түгээсэн юм, бусдад тарааж хүрэлцүүлэн өгөх юм; *түгээл өгөх; түгээл хүргэх;* **түгээл тоо** (хэд хэдээр гэдэг асуултад харилагдах тооны үг).

ТҮГЭЭЛГЭХ түгээхийн үйлдүүлэх хэв, түгээхэд хүргүүлэх.

ТҮГЭЭМЭЛ нийтэд тарж гүгсэн юм; *түгээмэл өвчин; түгээмэл болсон хэрэг;* **түгээмэл түүх** (нийт ард түмэнд хамаарагдах түүх).

ТҮГЭЭХ түгэхийн үйлдүүлэх хэв, түгэхэд хүргүүлэх.

ТҮДГЭЛЗҮҮЛЭХ түдгэлзэхийн үйлдүүлэх хэв.

ТҮДГЭЛЗЭХ 1. хийх үйл явдлын баахан азнах, хойшлох; *хөдөө явахаа түдгэлзэх; ажилд орохоо түдгэлзэх;* 2. санал хураахад саналаа өгөхгүй, бас ч татгалзахгүй үлдэх, *санал өгөхөө түдгэлзэх; санал хураахад түдгэлзсэн арваад хүн байв.*

ТҮДҮҮЛЭХ түдэхийн үйлдүүлэх хэв, түдгэлзүүлэх, хойшлуулах, азнуулах.

ТҮДЭХ 1. азнах, саатах, түдгэлзэх, хойшлох; *энэ өдөр явахаа баахан түдэх бололтой;* 2. удах; **удах түдэх** х о р ш.; **ихэс түдэх** (хүн төрөхэд ихэс гарахгүй удах).

ТҮДЭЭХ түдэхийн үйлдүүлэх хэв, түдэхэд хүргүүлэх, түдүүлэх.

ТҮЖГЭР 1. бие хомс ягжгар; *түжгэр бяруу; түжгэр хурга;* 2. өвсний таҥир богино; *түжгэр ургамалтай билчээр.*

ТҮЖИЙЛГЭХ түжийхийн үйлдүүлэх хэв, түжгэр болгох.

ТҮЖИЙХ түжгэр болох; *уяатай байгаа түжийсэн бор морь чинь хэний морь вэ? түжийсэн өвс билчээр муутай нутаг байв.*

ТҮЖИР I хатаж, хялбархан эс хэмхрэх, хатуу болсон идэшний зүйл; *түжир ааруул; түжир боов.*

ТҮЖИР II амьтны эдэлгээ даах тэсвэр сайтай нь; *унахад түжир морь; ажилд түжир хүн.*

ТҮЖИРЛҮҮЛЭХ түжирлэхийн үйлдүүлэх хэв.

ТҮЖИРЛЭХ түжир байдал гаргах, түжир байх.

ТҮЖРҮҮЛЭХ түжрэхийн үйлдүүлэх хэв.

ТҮЖРЭХ арьсны үс зулгааж зумлахад хялбар зулгарахгүй болох.

ТҮЙВҮҮЛЭХ түйвэхийн үйлдүүлэх хэв, самуурах алмайдахад хүргүүлэх, үймүүлэх.

ТҮЙВЭРГЭХ юмыг үймүүлэх, хутгах, сандаргах; *энэ хүүхэд номы минь бүр түйвэргэж орхижээ.*

ТҮЙВЭХ үймэх, сарних, самуурах, түвшин байдаа алдах.

ТҮЙВЭЭГЧ түйвээх этгээд.

ТҮЙВЭЭЛГЭХ түйвээхэд хүргүүлэх.

ТҮЙВЭЭХ түйвэхийн үйлдүүлэх хэв, түйвэхэд хүргүүлэх.

ТҮЙДҮҮЛЭХ 1. түйдэхийн үйлдүүлэх хэв; 2. түйдэгдэх.

ТҮЙДЭГДЭХ түйдэхийн үйлдэгдэх хэв.

ТҮЙДЭН: түйдэн хэлэлцэх энэлсэн шаналсныг мартуулан хэлэлцэх.

ТҮЙМЭР ослоор шатан дэгжиж үүсэх гал; **гал түймэр** х о р ш.; *түймэр идэх; түймэрт идэгдэх; түймэрт сүйдэх; түймрийн гал; түймрийн утаа; урагш муутыг усан дотроос түймэр авах* з ү й р; **түймэр цохих** (түймрийн галыг унтраахаар юм хүмээр дэлсэх); **түймэр тавих** (гал алдаж дэгжээх): **түймэр алдах** (ослоор гал гарч сөнөөн чадахгүйд хүрэх); **түймэр цуравдах** (гарсан түймрийн эсрэг гал шатаах); **түймрийн цурав** (түймэрт шатаж харалсан газар, цурам); **түймрийн цурам** (түймрийн цурав); **түймрийн уулга** (түймрийн гол хүчин).

ТҮЙМЭРДҮҮЛЭХ түймэрдэхийн үйлдүүлэх хэв.

ТҮЙМЭРДЭХ 1. галд юм хумыг шатаах; 2. ш и л ж с э н галыг хэтэрхий ихээр түлэх.

ТҮЙНЭГ элж элэгдэн мөр ирмэггүй болсон мөлгөр юм.

ТҮЙТГЭР тотгор, саад; **тотгор түйтгэр, түйтгэр саад** х о р ш.; *түйтгэр тохиолдох; түйтгэр хийх; түйтгэр болох.*

ТҮЙТГЭРЛҮҮЛЭХ 1. түйтгэрлэхийн үйлдүүлэх хэв; 2. түйтгэрлэгдэх.

ТҮЙТГЭРЛЭГДЭХ түйтгэрлэхийн үйлдэгдэх хэв.

ТҮЙТГЭРЛЭХ саад, тотгор болох; *миний ажилд түйтгэрлэх хэрэггүй.*

ТҮЙТЭХ түйтгэр тавих, түйтгэр болох, түйтгэрт орох, түйтгэрт учрах.

ТҮЛБЭРЭХ торох, түр зогсоохийх, зогсоно.

ТҮЛГЭХ үйл ажилд бие хайрлахгүй зүтгэн зүдэж явах; *манай малчид, мал маллах ажилд бие хайргүй түлгэсээр ирсэн сайхан заншилтай билээ.*

ТҮЛҮҮЛЭХ 1. түлэхийн үйлдүүлэх хэв; 2. түлэгдэх.

ТҮЛХЛҮҮЛЭХ түлхлэхийн үйлдүүлэх хэв.

ТҮЛХЛЭГ түлхээс.

ТҮЛХЛЭХ 1. юмыг байн байн түлхэх; 2. үйл явдлыг шалтаж зайлсхийн биедээ дааж авахгүй, байх.

ТҮЛХҮҮЛЭХ 1. түлхэхийн үйлдүүлэх хэв; 2. түлхэгдэх.

ТҮЛХҮҮР I цоож оньс зэргийн юмыг нээх зүйл; *цоожны түлхүүр; машины түлхүүр; цагны түлхүүр; түлхүүрийн оосор;* **нууц түлхүүр** (нууц бичгийг тайлж унших цагаан толгой).

ТҮЛХҮҮР II шавар шороо түлхлэн арилгах хэрэгсэл.

ТҮЛХЦЭХ үйл явдлыг харилцан бие биедээ хаялцах; *битгий түлхцээд бай; түлхцэх хэрэг алга, нэг нь хийчихвэл барав.*

ТҮЛХЧИХ 1. түлхэж орхих; *энэ модыг түлхчих; түлхчиж зайлуулаад суухгүй юу;* 2. түлхүүрээр нээх; *цаад цоожоо түлхчих, энэ түлхүүрээр түлхчиж болдог юм.*

ТҮЛХЭЛГЭЭ түлхэх үйлийн нэр: **түлхээс**; *түлхэлгээ хийх.*

ТҮЛХЭГДЭХ түлхэхийн үйлдэгдэх хэв.

ТҮЛХЭЛДЭХ түлхэхийн үйлдэлдэх хэв.

ТҮЛХЭЛЦЭХ түлхэхийн үйлдэлцэх хэв; *тэрэг түлхэлцэх.*

ТҮЛХЭХ 1. юмыг гарын зэргээр хүчлэн цааш болгох, түрэх; *түлхэж унагаах; цааш түлхлэх; гараараа түлхэх; тэрэг түлхэх;* 2. үйл явдлыг биедээ дааж авахгүй бусдад тулгах; *бусдад түлхэх; дүү нь ахдаа түлхэх;* 3. үйл хэрэгт хүнийг гадуурхаж үзэх; **татах түлхэх** хор ш.; *нэгий нь гадуурхаж түлхэх хэрэг юу?* 4. ус зэргийн үерлэж нэмэгдэх; *ус нилээд түлхжээ;* 5. цоож мэтийг түлхүүрээр нь нээх, хөдөлгөх; *цоож түлхэх; цаг түлхэх.*

ТҮЛХЭЦ түлхэх үйлийн явц; *түлхэц сайтай; түлхэц муухантай; ажилд түлхэц болох хэрэгтэй.*

ТҮЛХЭЭ тогтмол цагт тэнгэс далайн усны түвшин нэмэгдэх нь.

ТҮЛХЭЭЛЭХ тэнгэс далайн усны түлхээ болох.

ТҮЛХЭЭС 1. түлхэх юм; 2. юмыг хэвийн байдлаас хувирган өөрчлөхөд холбогдсон бусдын өдөөлт, хатгалга; *түлхээс оруулах; түлхээс хийх.*

ТҮЛХЭЭСЛЭХ түлхээс хийх.

ТҮЛХЭЭСТЭЙ түлхээс бүхий; *цаанаа зааваал түлхээстэй байх ёстой, хэрэв түлхээсгүй бол ингэж байхгүй.*

ТҮЛШ галд түлэхэд зориулж бэлтгэсэн түлээ, аргал, нүүрс зэрэг юм; *түлш бэлтгэх; түлш түүх; түлш авах; түлш зэхэх.*

ТҮЛЭГДЭХ түлэхийн үйлдэгдэх хэв, галд шатах.

ТҮЛЭНХИЙ түлэгдсэн юм; *түлэнхий нүүртэй; түлэнхий газар; түлэнхий мод; түлэнхий өнгө; түлэнхий үнэр; түлэнхий амт; түлэнхий сүү.*

ТҮЛЭХ юмыг галд шатаах ба халуун юманд хайрах; *тулганд гал түлэх; мод түлэх; цаас түлэх; гараа түлэх; дээлээ түлэх.*

ТҮЛЭЭ түлшинд зориулж бэлтгэсэн мод; **түлээ түлш** хор ш.; *түлээ хөрөөдөх; түлээ хагалах;* **түлээний сүх** (түлээ хагалах том сүх).

ТҮМ (ЭН) 1. тооны нэр, арван мянга; 2. маш, олон; *ард түмэн; түмэн ард; олон түмэн; түмэн улс; улс түмэн; түмний төлөө зүтгэх; түмэн зөв; түмэн үнэн; түмэн буруу;* **түмэн түм** (тооны нэр, нэг зуун сая); **түмэн зангилаа** ургамал (уул хярын жалга мэт баахан зөөлөн газар ургадаг ургамал, өндөр нь нэг тохой хир, салаа гишүү маш олон гарч салаа тутам чөдрийн уулзар мэт зүйл гурвалжлан салаалж бөөгнөрөн ургана, тэмээ ба бог мал бага зэрэг иднэ); **түмэн бодис** (одон гариг, манай дэлхий дээр байгаа бүх сав, шим ертөнц буюу амьтай, амигүй бодис).

ТҮМБИЙЛГЭХ түмбийхийн үйлдүүлэх хэв, түмбэгэр болгох.

ТҮМБИЙХ түмбэгэр болох.

ТҮМБЭГНЭХ түмбэгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ТҮМБЭГЭР түнтгэр, томбогор; *түмбэгэр уул; түмбэгэр сав.*

ТҮМБЭЛЗЭХ түмбэгэр юмны байн байн хөдлөх.

ТҮМД өвөр монголын нэгэн аймгийн нэр.

ТҮНГЭ түрийд хадаж тэлээнд уях оосор.

ТҮНГЭРЦЭГ хуцын хуухаар хийсэн сав.

ТҮНГЭРЦЭГЛҮҮЛЭХ түнгэрцэглэхийн үйлдүүлэх хэв.

ТҮНГЭРЦЭГЛЭХ хэвэл гэдэс бүдүүрч том болох.

ТҮНИЙДҮҮЛЭХ түнийдэхийн үйлдүүлэх хэв.

ТҮНИЙДЭХ тэрэгний хойд талд ачсан юм хүнддэж өргүүхэн болох.

ТҮНПЭН гадар, өргөн гүнзгий биш дугуй төмөрлөг сав; *гурил зуурах түнпэн; гар нүүрийн түнпэн.*

ТҮНСГЭР түнтгэр.

ТҮНСИЙЛГЭХ түнсийхийн үйлдүүлэх хэв, түнсгэр болгох.

ТҮНСИЙХ тэлэгдэж түнгэрцэглэх, түмбэгэр болох.

ТҮНСЭХ тариаиы мөхөлгийг цохиж унаглаах; *тариа түнсэх.*

ТҮНТГЭР бөөрөнхийвтөр, бондгор, бөндгөр, түнсгэр; *хүүдийтэй түнтгэр юм; түнтгэр толгойт Маамтайгаа уулзаад гаръя* (дуунаас).

ТҮНТИЙЛГЭХ түнтийхийн үйлдүүлэх хэв, түнтгэр болгох.

ТҮНТИЙХ түнтгэр болох; *түнтийтэл багласж орхижээ.*

ТҮНТЭГ бууз мэт нэг зүйлийн хоол, тосонд чанана.

ТҮНТЭГНЭХ түнтгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ТҮНТЭЛЗЭХ түнтгэр юмны байн байн хөдлөх.

ТҮНХ хүн малын сүүжний хонхорт угласан дунд чөмөгний булууны үзүүрийн бөөрөнхий яс ба сүүж чөмөг хоёрын уулзар газар; *түнхээр хатгах.*

ТҮНХГЭР цэндгэр, түмбэгэр байдалтай юм, томбогор, товгор; *түнхгэр гэдэстэй хүн; савтай түнхгэр юм.*

ТҮНХИЙЛГЭХ түнхийхийн үйлдүүлэх хэв, түнхгэр болгох.

ТҮНХИЙХ түнхгэр болох, түмбийх, томбойх, товойх; *өвөр дотор нь нэг юм түнхийж байв.*

ТҮНШ 1. х у у ч и р с а н худалдааны ажилд дотно найзархаг, нөхөрсөг; *түншээс зээл авах;* 2. дотно, найзархаг нөхөр; *түнш хүн; түнш пүүс.*

ТҮНШИГДЭХ түншихийн үйлдэгдэх хэв.

ТҮНШИХ 1. түншүүрээр дэлдэх; *хушийг түншиж самры нь унагаах; оготныи ордыг түнших;* 2. ш и л ж с э н төсөвлөн мэдэх, туршин төсөвлөх; *битүүгээр түншээд үзэв.*

ТҮНШЛЭХ түнш болох.

ТҮНШҮҮЛЭХ 1. түншихийн үйлдүүлэх хэв; 2. түншигдэх.

ТҮНШҮҮР хушийг дэлдэж самры нь унагаах зэвсэг; *самрын түншүүр; түншүүр муна.*

ТҮНШҮҮРДҮҮЛЭХ түншүүрдэхийн үйлдүүлэх хэв.

ТҮНШҮҮРДЭХ түнших, түншүүрээр дэлдэх.

ТҮНЭР хав хар үзэгдэх байдал **хар түнэр** х о р ш.; *түнэр хар царайтай; түнэр хар модтой газар.*

ТҮНЭРТЭХ хав харлан үзэгдэх; *түнэртсэн хар үүл гарч байна, ширүүн бороо орох биз ээ; түймэрт шатсан газар түнэртэн харагдаж байв.*

ТҮР I хэсэг зуур, удаан биш; *түр зуурын явдал; түр орших; түр хүлээ; түр хэдэн хоногоор явах; түр засгийн газар; түр сургууль;* **түр цэрэг** (богино хугацаагаар алба хаах цэрэг).

ТҮР II: **түр тар**, нир хийх чимээ; *түр тар хийх чимээ гарав; түр тар хийгээд явчихав, юун чимээ вэ?*

ТҮРГЭДҮҮ дэндүү түргэн зантай; *түргэдүү хүн.*

ТҮРГЭДҮҮЛЭХ түргэдэхийн үйлдүүлэх хэв. хэв.

ТҮРГЭДЭХ хэтэрхий түргэн болох, хурдандах, яаруудах.

ТҮРГЭЛҮҮЛЭХ түргэлэхийн үйлдүүлэх хэв, түргэн болгох.

ТҮРГЭЛЭХ түргэн болох, хурдлах, яарах; *түргэлж үзээрэй, галт тэрэг хөдлөх болов.*

ТҮРГЭН хурдан: **хурдан түргэн, бушуу түргэн** х о р ш.; *түргэн явж түргэн хүрэх; түргэн гол адагтаа хүрдэггүй* з ү й р; **түргэн зан** (яаран догшрох уурлах зан); **түргэн буцалгагч** (хурдан буцалгах сав); **түргэн ус** (урсгал ширүүн ус); **түргэн өвчин** (доройтуулах хурдан өвчин); **түргэн тусламж** (аюултай өвчин, осол зэрэгт эмнэлгийн яаралтай туслалцаа

үзүүлэх байгууллага); **түргэндээ орох** (шуудрах, шулуудах); **түргэн түүхий** (юмыг яаруу, тэвдүү, хааш яаш хийх); **түргэн цагаан** (ямаахай).

ТҮРГЭСГЭХ түргэсэхийн үйлдүүлэх хэв, түргэсгэх.

ТҮРГЭСЭХ улмаар түргэн болох.

ТҮРГЭТГЭХ түргэтэхийн үйлдүүлэх хэв, түргэтгэх.

ТҮРГЭТЭХ улмаар түргэн болох, түргэсэх.

ТҮРГЭЧ түргэн зан байдалтай; *түргэч хүн; түргэч морь.*

ТҮРД: түрд хийх, түрд гэх чимээ; *байшингийн хаалга түрд хийв.*

ТҮРДХИЙХ 1. түрд тард чимээ гарах; *ятуу түрдхийн нисэв;* 2. ш и л ж с э н гэнэт татан, угзран авах; *түрдхийтэл татан авлаа.*

ТҮРДЭХ эвдэрч үрэгдэх, эвдрэн өнгөрөх.

ТҮРИЙ гутлын зулагны дээд хэсэг буюу оймсны шилбийг бүрхэх хэсэг; *түрийтэй ботинк; урт түрийтэй гутал;* **өвөр түрийдээ орох** (маш дотно болж гэр гэрээрээ хэсүүчлэх); **хошногын түрий** (тэнэг түрүү).

ТҮРИЙВЧ 1. мөнгө цаас агуулж биедээ авч явах сав; *түрийвчтэй мөнгө;* 2. бичиг агуулах сав.

ТҮРИЙВЧЛҮҮЛЭХ түрийвчлэхийн үйлдүүлэх хэв.

ТҮРИЙВЧЛЭХ түрийвчид хийх, агуулах.

ТҮРИЙЛҮҮЛЭХ түрийлэхийн үйлдүүлэх хэв.

ТҮРИЙЛЭХ юмыг гутлын түрийд хийх; *гансаа түрийлээд босов.*

ТҮРЛЭГ 1. уртын дууны нэг бадаг; *гурван түрлэг дуулах;* 2. найрлахад нэг түрлэг дуулсны дараа олноороо аялах, дуулах, түрэх нь; *дууч дуулж гүйцмэгц «Түрлэг айлтгая» гэв.*

ТҮРС загасны өндөг; *загасны түрс;* **түрс орхих** (загасны өндөглөх).

ТҮРҮҮ (Н) I тарианы мөхлөгтсөн саглагар үзүүр; *тарианы түрүү.*

ТҮРҮҮ (Н) II саяхан, тун саявтар, урьдхан, өмнөхөн; *түрүү би танайд ирээд явлаа; түрүүнд нэг хүн чамтай уулзах гэж ирсэн; бид аль түрүүнд машинаар ирсэн; бороонь түрүүнд шороо, богдын түрүүнд элч з ү й р.*

ТҮРҮҮ III 1. толгой, тэргүүн; **толгой түрүү** х о р ш.; *түрүү сүүлгүй их байна;* **тэнэг түрүү** (малын хошногогын бүдүүн үзүүр, алганагийн орчин газар); 2. ш и л ж с э н тэргүүн, манлай, урьдсан юм; *түрүүний гарсан чихнээс сүүлийн гарсан эвэр хатуу з ү й р.*

ТҮРҮҮЛҮҮЛЭХ түрүүлэхийн үйлдүүлэх хэв.

ТҮРҮҮЛЭГЧ түрүүлсэн юм; *түрүүлэгч хүн; түрүүлэгч морь.*

ТҮРҮҮЛЭХ I тариа ургамалд түрүү гарах, түрүүгэх; *тариа түрүүлэх.*

ТҮРҮҮЛЭХ II тэргүүлэх, түрүүнд нь орох.

ТҮРҮҮЛЭХ III түрэхийн үйлдүүлэх хэв; 2. түрэгдэх.

ТҮРҮҮТЭХ тариа, ургамалд түрүү гарах; *тариа түрүүтэх.*

ТҮРҮҮЧ I 1. эхэн хэсэг, түрүү хэсэг; *хонио хэд хувааж түрүүчийн хэсгийг услаад дараа нь... түрүүчийн цас;* 2. саяны саяын; *түрүүчийн машинтай даргыг чинь хэн гэдэг юм бэ?*

ТҮРҮҮЧ II цэргийн бага даргын цол; *бага түрүүч; ахлах түрүүч;*

ТҮРХЛЭХ байн байн түрхэх.

ТҮРХМЭЛ түрхсэн юм; *алт түрхмэл ширээ; түрхмэл будаг; маажин түрхмэл.*

ТҮРХҮҮЛ түрхдэг юм, түрхүүр.

ТҮРХҮҮЛЭХ 1. түрхэхийн үйлдүүлэх хэв; 2. түрхэгдэх.

ТҮРХҮҮР түрхэх зэвсэг, түрхүүл; *түрхүүрээр түрхэх.*

ТҮРХЭГДЭХ түрхэхийн үйлдэгдэх хэв.

ТҮРХЭЛТ түрхсэн байдал.

ТҮРХЭХ наалдуулах, нялах; *будаг түрхэх; цавуу түрхэх; алт түрхэх; тос түрхэх; давс түрхэх; ус түрхэх.*

ТҮРХЭЦ 1. алт мөнгө зэргийг түрхэж наалдуулсан нь; *түрхэц алт;* **түрхэцтэй, шармал** (алт шарсан); 2. микроскопоор шинжлэхийн тул шил дээр нимгэн наалдуулсан шингэн ялгадасны зүйл; *хоолойн түрхэц.*

ТҮРЧИГНҮҮЛЭХ түрчигнэхийн үйлдүүлэх хэв.

ТҮРЧИГНЭХ түр тар хийх чимээ гарах; *тэрэг түрчигнэх сонсдов.*

ТҮРЧИХ I арчих; **арчих түрчих** х о р ш..

ТҮРЧИХ II 1. нэгэнт түрэх; 2. байн байн түрэх.

ТҮРЭГДЭХ түрэхийн үйлдэгдэх хэв.

ТҮРЭЛХИЙЛЭХ 1. хүний оморхон давшлах; 2. морь малын тэлүүлхилэн зүтгэх.

ТҮРЭМГИЙ 1. ааглуу зантай, дээрэнгүй; *түрэмгий зан гаргах;* 2. харгис, эзэрхэг; **эзэрхэг түрэмгий** х о р ш.; *түрэмгий дайн дэгдээх.*

ТҮРЭМГИЙЛҮҮЛЭХ 1. түрэмгийлэхийн үйлдүүлэх хэв; 2. түрэмгийлэгдэх.

ТҮРЭМГИЙЛЭГДЭХ түрэмгийлэхийн үйлдэгдэх хэв.

ТҮРЭМГИЙЛЭГЧ түрэмгийлдэг этгээд

ТҮРЭМГИЙЛЭХ түрэмгий зан гаргах, дарлах, дээрэнгүйлэх; *түрэмгийлэн эзлэгч.*

ТҮРЭМГИЙРҮҮЛЭХ түрэмгийрэхийн үйлдүүлэх хэв, түрэмгий болоход хүргүүлэх.

ТҮРЭМГИЙРЭХ түрэмгий болох, түрэмгий байдал гаргах.

ТҮРЭМГИЙЧҮҮД түрэмгийлэгчид; *эзэрхэг түрэмгийчүүд.*

ТҮРЭХ I 1. хойноос нь түлхэх; **түрж түлхэх** х о р ш.; *тэрэг түрэх;* 2. түрэмгийлэх; **түрэх түрэмгийлэх** х о р ш.; *чи битгий түрээд бай; намайг түрэх хэрэг юу билээ.*

ТҮРЭХ II уртын дууны нэг бадгийг дуулж гүйцэнийн дараа олуулаа ая аялах.

ТҮРЭЭС юмнаас хураасан гайль татвар; **гайль түрээс, түрээс татвар** х о р ш.; *газрын түрээс; ойн түрээс; давсны түрээс; түрээс тогтоох.*

ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧ түрээслэн өгөгч этгээд.

ТҮРЭЭСЛҮҮЛЭХ түрээслэхийн үйлдүүлэх хэв.

ТҮРЭЭСЛЭГЧ түрээслэн авч өгөгчид.

ТҮРЭЭСЛЭХ түрээстэй болох; *түрээслэн авах; түрээслэн өгөх; газар түрээслэх.*

ТҮС: түс хийх хүнд жинтэй юмны унах чимээ; *богцоо түс хийтэл шидэж орхив. түс тас хийх;* **түс тас** (шулуун, шууд, шудрага; *түс тас хэлж орхив).*

ТҮСГИЙЛГЭХ түсгийхийн үйлдүүлэх хэв.

ТҮСГИЙХ 1. хөөнгөрөх, хөөх, цэндгэр бүдүүн болох; 2. ш о о д с о н таргалах; **түсгийж хэвтэх** (дэмий хэвтэх).

ТҮСГЭГЭР тэсгэгэр.

ТҮСРҮҮЛЭХ түсрэхийн үйлдүүлэх хэв.

ТҮСРЭГ цардах, шүршихэд хэрэглэх сав.

ТҮСРЭХ 1. сав дахь усыг бүрмөсөн асгах; 2. газар цардах; *ус түсрэх.*

ТҮСЭРГҮҮЛЭХ түсэргэхийн үйлдүүлэх хэв.

ТҮСЭРГЭХ түсрэхэд хүргүүлэх, түсрүүлэх.

ТҮҮВЭР 1. энд тэндээс авч нийлүүлсэн юм, цуглуулга; **үүвэр түүвэр** х о р ш.; 2. зохиол, баримт бичгийн зүйлийг цугларуулан хамтатгасан ном; *шүлгийн түүвэр; түүвэр зохиол.*

ТҮҮВЭРЛҮҮЛЭХ түүвэрлэхийн үйлдүүлэх хэв.

ТҮҮВЭРЛЭХ энд тэндээс цугларуулан авах; *түүвэрлэн бичих; түүвэрлэн цуглуулах.*

ТҮҮГЭЭР 1. хүүрнэж бий аливаа юмны зайдуу байгааг заах үг; *түүгээр юу хийх вэ;* 2. тэр орчмоор, тэр талаар; *биднийг түүгээр явж байхад; үүгээр түүгээр явах;* 3. тийм байдлаар; тэр байдлаар; *түүгээр бол ч бүтэхгүй байх аа; түүгээр бодвол ...* **түүгээр үл барам** (чингээд ч зогссонгүй); 4. тэндээ, тэр зуурын; *түүгээрээ гүйцэтгэх хэрэгтэй; түүгээр шийдвэрлэ!*

ТҮҮД: түүд болох бялдуучилъя гэвч айж бэрхшээх.

ТҮҮДРЭХ түгдрэх.

ТҮҮДЭГ I хээр түлсэн гал; *түүдэг галын дэргэд сууж байв.*

ТҮҮДЭГ II томох үс хялгасыг бөөгнөрүүлж бэлтгэсэн нь; *түүдэг хийх; унгасан түүдэг; хялгасан түүдэг.*

ТҮҮДЭГ III: **түүдэг өвчин** хонь малын шээс хаагдах өвчин.

ТҮҮДЭГЛЭХ 1. үс хялгас томоход бэлтгэж гонзгор бөөрөнхий болгох; *хялгас түүдэглэх;* 2. бага хүүхдийг юманд суулгаж арчд үүрэглэх.

ТҮҮДЭГТЭХ түүдэг өвчин тусах.
ТҮҮДЭЭ түүд, түвдэл.
ТҮҮДЭЭГҮЙ огт түвдэлгүй.
ТҮҮДЭЭРХЭХ андуурах.
ТҮҮДЭЭРЭЛ түүдээрэх үйлийн нэр.
ТҮҮДЭЭРЭХ сэжиглэн таамнагалзаж, саная хоёр үзүүртэй болох; **түүдээрэлгүй** (торж түлбэрэхгүй).
ТҮҮН тэр гэдэг үгний харъяалах, өгөх орших, заах, гарах, хамтрахын тийн ялгалын дагавартай орох үндэс; *түүний гэр; түүнд өрөх; түүнийг дуудах; түүнээс хойш; түүнтэй хамт явав.*
ТҮҮНИЙХ тэр гэдэг үгийн хамаадуулах дагавартай харъяалахын тийн ялгалын хэлбэр, түүнд холбогдох, түүнд хамаарагдах юм; *энэ эмээлтэй морь түүнийх.*
ТҮҮНЧЛЭН тэр мэт, мөн адил, мөн, бас; *түүнчлэн бидэнд цааш явах уналга олдохгүй байна.*
ТҮҮР: үүр түүр, бүүр түүр тодорхой биш, бүдэг бадаг; *тэр жилийн явдал үүр түүр санагдах юм.*
ТҮҮРХИЙ хагархай, хэмхэрхий, эмтэрхий.
ТҮҮРЭГ I хотын гадуур орших суурин газар; *Улаанбаатар хотын түүрэгт.*
ТҮҮРЭГ II хүүрэг.
ТҮҮРЭГДҮҮЛЭХ түүрэгдэхийн үйлдүүлэх хэв.
ТҮҮРЭГДЭХ түүрэхийн үйлдэгдэх хэв.
ТҮҮРЭХ хялбархан хэмхрэх, бяцрах, эмтрэх.
ТҮҮХ (ЭН) I 1. нийгэм-байгалийн өнгөрсөн үе ба хөгжлийн тухай шинжлэх ухаан; **түүх судар, түүх шашдир** хорш.: *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх; дундад эртний үеийн түүх; түүхийн тинхим; түүхийн анги; түүх судлаач; түүхэн роман; түүхэн үе;* 2. ер бишийн явдал, тохиол; *их түүхтэй явдал болоо;* 3. намтар; **түүх намтар** хорш.; *түүхээ түүхээ ярих, гурван үеийн түүх.*
ТҮҮХ II энд тэндээс цуглуулж хураан авах; *жимс түүх; мөөг түүх; аргал түүх.*
ТҮҮХИЙ I биед гарах яр, нясуу; *хүүхдий нь нүүр дээр түүхий гарсан байв; түүхийний тос.*

ТҮҮХИЙ II 1. идэх юмны чанаж болгож гүйцээгүй, дутуу чанасан нь; *түүхий мах; гурил нь түүхий байна;* 2. жимсний боловсорч гүйцээгүй; *намар эрт мойл түүхий байдаг; түүхий алим;* ☆ **түүхий будаа** (шар будаа); **түүхий шохой** (устай холиогүй шохой); **түүхий эд** (цаашдаа үйлдвэрийн газар боловсруулахад зориулсан материал; *барилгын түүхий эд; хөдөө аж ахуйн түүхий эд*); **түүхий тоосго** (шүүслээгүй тоосго); 3. шилжсэн гүйцэд сайн болж боловсорч чадаагүй, дутуу дулим; *энэ зохиол бас л түүхий байна;* **түүхий хэрэг** (боловсорч тодроогүй хэрэг); **түргэн түүхий явдал** (хуусдуу үйл ажил); 4. зарим өвчнөөр өвдөж боловсроогүй юм; *цэцэг өвчинд боловсроогүй түүхий хүүхэд; мялзанд боловсроогүй түүхий үхэр.*
ТҮҮХИЙДҮҮЛЭХ түүхийдэхийн үйлдүүлэх хэв, түүхий болоход хүргүүлэх.
ТҮҮХИЙДЭХ хэтэрхий түүхий болох; *мах түүхийдээд идэж болсонгүй.*
ТҮҮХИЙРҮҮЛЭХ түүхийрэхийн үйлдүүлэх хэв, түүхийрэхэд хүргүүлэх.
ТҮҮХИЙРЭХ I 1. түүхий болох; 2. идэх уух юм гэнэт хувилж муудах.
ТҮҮХИЙРЭХ II бие дээр түүхий, яр гарах.
ТҮҮХТ түүх бүхий; *түүхт хүн; түүхт явдал; түүхт өдөр.*
ТҮҮХЧ түүх судлагч, түүх мэддэг.
ТҮҮХЭН тэрүүхэн; *түүхэнд нарийлаад юу хийнэ? түүхнээр чинь яах юм?*
ТҮҮЧЭЭ аян жинд хөтөлж явахад тэргүүлэн явах мал; *түүчээ шар.*
ТҮҮШ 1. араа шүдний мохоолын газар; 2. түүшүү; 3. эрүүний үглуурга орчин газар; **түүш авах** (түүшийг алгадах).
ТҮҮШҮҮ түүш; **түүшүү багалзуур** хорш.; **түүшүү зуурах** (ам ангайж үл болох); **түүшүүгий нь шахах** (багалзууры нь шахах).
ТҮҮШҮҮДЭХ 1. түүшүүг шаах; 2. жанчих зодох.
ТҮХГЭР 1. лухгар, тарган, бүдүүн; 2. цондгор, цүндгэр; *түхгэр хэвэлтэй.*
ТҮҮХИЙЛГЭХ түүхийхийн үйлдүүлэх хэв, түхгэр болгох.
ТҮХИЙХ түхгэр болох; *түхийсэн гарсан шар харагдав, гэдэс нь түхийх.*

ТҮШГЭРЭХ бог малыг дуудахад гаргах аялга; *хонь түшгэрэх.*

ТҮШИГ түшвэл болох газар, юм; **түшиг тулгуур** х о р ш.; *түшиг муутай; түшиг сайтай.*

ТҮШИГГҮЙ түших, тулах зүйлгүй.

ТҮШИГГҮЙДЭХ түшиг тулгуургүйдэх.

ТҮШИГДЭХ түшихийн үйлдэгдэх хэв.

ТҮШИГЛҮҮЛЭХ түшиглэхийн үйлдүүлэх хэв; *ахыг түшиглүүлэн дүүгээ хөдөө явуулав.*

ТҮШИГЛЭХ үйл явдалд бусдыг итгэж түшиг болгох.

ТҮШИГТЭЙ түших тулах зүйл бүхий, түшиг тулгуур сайтай.

ТҮШИХ 1. юманд тулж налах, хажуулах; *ширээ түших;* 2. аж төрөх, хайгуул халхавч болгох зэрэг аливаа үйл явдалд бусдыг итгэн түшиглэх; *ахыг түшихээс өөр арга зам алга;* 3. хазайсан буюу тогтвор муутай юмыг тулах, дэмнэх, зэргээр тогтоход хүргүүлэх, тогтоох; *хазайхад түших, халтирахад тулах* з ү й р.

ТҮШЛЭГ хүний түшиж суухад хэрэглэх зүйлийн нэр; *арын түшлэг; гарын түшлэг; олбог түшлэг.*

ТҮШЛЭГТ түшлэг бүхий; *олбог түшлэгт ширээнд ихэмсэг байдлаар суув.*

ТҮШЛЭГТЭЙ түшлэг бүхий; *түшлэгтэй сандал.*

ТҮШМЭД түшмэл, олон түшмэл.

ТҮШМЭЛ урьдын цагт албаны үүргийн талаар таслах тогтоох явдалд оролцох эрх тушаал бүхий хүн; *эрхэлсэн түшмэл; дээлэх түшмэл; туслах түшмэл; түшмэл түших; түшмэл эвдэх.*

ТҮШҮҮЛЭХ 1. түшихийн үйлдүүлэх хэв; 2. түшигдэх.

ТҮШЭЭ: түшиг түшээ гүн х у у ч и р с а н (Манжиин үеийн хэтэрхий дөрвөн хэргэмийн дөрөвдүгээр зэрэг).

ТЭВ I: **тэв тав хийх, тэв тэв алхлах** хөнгөн гавшгай байдалтай алхах, хөдлөх; *тэв тэв хийтэл алхалсан сүрхий өвгөн байна;* **тэв хийтэл** (юмыг цомхон, аятай эмхэлсэн; *тэв хийтэл хураасан ном харагдав*).

ТЭВ II хүч нэмэгдүүлэх үг; *тэв тэгш; тэв тэвхэр.*

ТЭВДҮҮ яаруу, сандруу, тэвдээ, бачим зантай.

ТЭВДҮҮЛЭХ тэвдэхийн үйлдүүлэх хэв, тэвдэхэд хүргүүлэх.

ТЭВДЭЛ тэвдэх үйлийн нэр.

ТЭВДЭХ 1. яарч сандрах, бачимдах; *би шалгалтад орохдоо их тэвдэв;* 2. ажил явдалд үүртэж зүй зохисыг олохгүй байх.

ТЭВДЭЭ тэвдүү.

ТЭВНЭ I юм оёх бүдүүн зүү; **зүү тэвнэ** х о р ш..

ТЭВНЭ II а м ь т а н бие маш нарийн, урт нь 60 см. орчим, өнгө боровтор, орчин төйрны өнгө байдлаар хувилдаг нэгэн зүйл загас.

ТЭВРЭЛ тэврэх үйлийн нэр.

ТЭВРЭЛДЭХ тэврэхийн үйлдэлдэх хэв.

ТЭВРЭЛЦЭХ тэврэхийн үйлдэлцэх хэв.

ТЭВРЭХ аливаа юмыг өвчүүнд түлгаж хоёр гар буюу хөлөөр хэт ороох; *хүүхэд тэврэх; тэврэн золгох;* **элгээ тэврэх** (хоёр гараа элэгний тус газар зөрүүлдэх): **өвчүүгээ тэврэх** (элэг тэврэх).

ТЭВХ I юмны завсар нь хавчуулж хөндийлөх зүйл; *нумны хөвчний тэвх; хөгжмийн чавхдасны тэвх; үүдний тэвх.*

ТЭВХ (ЭН) II: **тэвх цай** шахмал том цайг жижиглэж дөрвөлжин болгосон хэсэг.

ТЭВХГЭР 1. товхгор зузаалаг байдалтай юм; *тэвхгэр хайрцаг; тэвхгэр ширээ; тэвхгэр ном;* 2. хөнгөн шаламгай хөдөлгөөнтэй.

ТЭВХГЭРДҮҮЛЭХ тэвхгэрдэхийн үйлдүүлэх хэв.

ТЭВХГЭРДЭХ хэтэрхий тэвхгэр болох, товхгордох.

ТЭВХДҮҮЛЭХ тэвхдэхийн үйлдүүлэх хэв.

ТЭВХДЭХ юмыг тэвхээр хөндийлөх, сөхөх; *үүд тэвхдэх.*

ТЭВХИЙЛГЭХ тэвхийхийн үйлдүүлэх хэв, тэвхгэр болгох.

ТЭВХИЙХ тэвхгэр болох.

ТЭВХЛҮҮЛЭХ тэвхлэхийн үйлдүүлэх хэв.

ТЭВХЛЭХ I тэвхдэх.

ТЭВХЛЭХ II юмыг дөрвөлжин болгож хэрчих; *мах тэвхлэх.*

ТЭВХЭГНЭХ тэвхгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ТЭВХЭЛЗҮҮЛЭХ тэвхэлзэхийн үйлдүүлэх хэв.

ТЭВХЭЛЗЭХ хүний хөдлөх, явах нь шалмгай байх; *тэвхэлзсэн сүрхий эр явж харагдав.*

ТЭВХЭР 1. тэвхгэр, товхгор; 2. юмыг тэвхэрлэхий нь; 3. дөрвөлжин.

ТЭВХЭРДЭХ хэтэрхий тэвхгэр болох, товхгордох.

ТЭВХЭРЛҮҮЛЭХ тэвхэрлэхийн үйлдүүлэх хэв.

ТЭВХЭРЛЭГ тэвхэрлэсэн нь; *тэвхэрлэг сайтай; тэвхэрлэг муутай.*

ТЭВХЭРЛЭХ I хүүхэд багачууд, өвгөд настан, өвчтөн зэргийг арчлан харгалзах.

ТЭВХЭРЛЭХ II юмыг тэвхгэр дөрвөлжин болгох, эмхлэх, өөд нь татах.

ТЭВХЭЭ: тэвхээ газар төрөлх чийгтэй нойтон болоод устай, өвс ургасан газар; зүлэгт газар ч гэдэг.

ТЭВЧИГДЭХҮҮН тэвчилтэй юмс.

ТЭВЧИЛ тэвчих үйлийн нэр, тэвчээр.

ТЭВЧИЛГҮЙ тэвчил, тэвчээр муутай буюу байхгүй.

ТЭВЧИЛТЭЙ тэвчил, тэвчээр сайтай, тэвчвэл зохилтой.

ТЭВЧИХ 1. юмыг мартаж, гээж, оорах, тэсвэрлэн өнгөрүүлэх; 2. үйл явдлыг цээрлэн үл үйлдэх; *амь тэвчих; буруу үйлийг тэвчих;* 3. хайрлах, харамлахгүй байх; *өгч тэвчих; эвдэж тэвчих.*

ТЭВЧҮҮЛЭХ тэвчихийн үйлдүүлэх хэв.

ТЭВЧЭЭР I хүлцэл, тэсвэр; *тэвчээр сайн; тэвчээр муу.*

ТЭВЧЭЭР II гутлын ул зулаг хоёрын хооронд барьж оёх сарьс илэг мэт юм.

ТЭВЧЭЭРГҮЙ хүлцэл тэсвэргүй, хүлцэл тэсвэр муу; *дэмий юм ярьдаг яасан тэвчээргүй хүн бэ.*

ТЭВЧЭЭРЛҮҮЛЭХ тэвчээрлэхийн үйлдүүлэх хэв.

ТЭВЧЭЭРЛЭХ I тэвчээр гаргах, хүлцэх.

ТЭВЧЭЭРЛЭХ II гуталд тэвчээр хийх.

ТЭВЧЭЭРТЭЙ хүлцэл тэсвэр сайтай, хүлцэлтэй.

ТЭВШ идэш идээний зүйлийг агуулах сав, модыг ухаж буюу зүйж хийнэ, хэлбэр уртлаг.

ТЭВШТЭЙ тэвш бүхий.

ТЭВЭГ 1. морь малын хялгас үс, тахианы өрөвлөг зэргийн юмыг зоос мэтэд хадан тогтоож өшиглөж наадах юм; *тэвэг наадах;* **тэвэг өшиглөх** (тэвгийг хөлөөр өшиглөн дээш үсэргэх); 2. хүний үс авах, морины дэлийг засахад толгойн оройд үлдээсэн урт бут үс; **тэвэг тавих** (толгойн оройд тэвэг үлдээх).

ТЭВЭР хүний нэг гар буюу хоёр гараар тэврэн барих хэмжээтэй юм; *нэг тэвэр түлээ; нэг тэвэр будуун мод; тэвэр дуурэн.*

ТЭВЭЭР тэвээрэг, тарга.

ТЭВЭЭРТЭЙ тэвээр сайтай, тэвээрэгтэй.

ТЭВЭЭРҮҮЛЭХ тэвээрэхийн үйлдүүлэх хэв.

ТЭВЭЭРЭГ малын тарга хүч, тэвээр; **тарга тэвээрэг** х о р ш..

ТЭВЭЭРЭЛ тэвээрсэн нь, тэвээрэг.

ТЭВЭЭРЭЛТЭЙ тэвээрэл тэвээрэг сайтай.

ТЭВЭЭРЭХ таргалах; *ногоо цухуйж мал тэвээрч эхлэв.*

ТЭГ 1. тооны тэмдэг, о, бянт ч гэнэ; 2. хоосон гэсэн санаа.

ТЭГ II хүч нэмэгдүүлэх үг; тэн, яг; *тэг дундуур; тэг голоор нь.*

ТЭГ III зөвшөөрөх аялга; *би кино үзэх үү, ээж ээ? тэг ээ, тэг, хүү минь.*

ТЭГДГЭР тагдгар, тогдгор, пагдгар.

ТЭГДИЙЛГЭХ тэгдийхийн үйлдүүлэх хэв.

ТЭГДИЙХ тэгдгэр болох, тагдайх, тогдойх, пагдайх.

ТЭГДЭГНҮҮЛЭХ тэгдэгнэхийн үйлдүүлэх хэв.

ТЭГДЭГНЭХ тэгдгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ТЭГДЭЛЗҮҮЛЭХ тэгдэлзэхийн үйлдүүлэх хэв.

ТЭГДЭЛЗЭХ тэгдгэр юмны байн байн хөдлөх.

ТЭГНҮҮЛЭХ тэгнэхийн үйлдүүлэх хэв.

ТЭГНҮҮР хүндийг хэмжих нэгэн зүйл хэмжүүр, пинс ч гэнэ.

ТЭГНҮҮРДҮҮЛЭХ тэгнүүрдэхийн үйлдүүлэх хэв.

ТЭГНҮҮРДЭХ тэгнүүрээр хэмжих.

ТЭГНЭХ 1. малд ачаа тэнцүүлэн ачих; *ачаагаа тэгнэх; тэгнэж ачих;* 2. юман дээгүүр тохсон мэт болох; *хүүхэд хашаа тэгнэх;* 3. тэгнүүрээр хэмжих;

ТЭГНЭЭ тэн, тэнцүүлж ачих ачааны нэг тал.

ТЭГШ 1. илүү дутуугүй адил; *тоо тэгш; тэгш эрх; тэгш байдал;* 2. хазгайгүй; *тэгш ширээ; тэгш газар; тэгш тал;* 3. муруйгүй шулуун, шууд; *тэгш шугам; тэгш мод;* **таван хуруу тэгш** (юм бүрд тэгш сайн).

ТЭГШДЭХ хэтэрхий тэгш болох, муруй хазгай юмны тэгш шулуун болох.

ТЭГШИТГЭЛ тэгшитгэсэн нь; *тэгшитгэл хийх;* **тооны тэгшитгэл** (нэг буюу хэд хэдэн үл мэдэгдэх хэмжигдэхүүн бүхий тэнцэтгэл).

ТЭГШИТГЭХ 1. юмыг нийгэм адил тэгш болгох; *алба тэгшитгэх;* 2. хазгай гажуу, илүү дутууг нэг мөр болгож тэгшлэх;; *илүү дутууг аар нь тэгшитгэх;* 3. юмыг тус тусын хир чинээнд тохируулан таацуулах; *үний нь таацуулан тэгшитгэх.*

ТЭГШЛҮҮЛЭХ тэгшлэхийн үйлдүүлэх хэв.

ТЭГШЛҮҮР тэгшилдэг буюу тэгш болгодог юм.

ТЭГШЛЭХ тэгш болгох; *газар тэгшлэх; хазгай юмыг тэгшлэх; алба тэгшлэх; үнэ тэгшлэх; муруйгий нь тэгшлэх;* **өрх тэгшлэх** (гэрийн өрхийг бүтээх).

ТЭГШРҮҮЛЭХ тэгшрэхийн үйлдүүлэх хэв.

ТЭГШРЭХ тэгш болох; *одоо алба тэгширчээ; шал тэгшрэх; газар тэгшрэх.*

ТЭГШТЭХ улмаар тэгш болох.

ТЭГШХЭН нилээд тэгш.

ТЭГЭХ чингэх, ингэх; *тэгж хийх; би тэгэх гэж бодож байсан.*

ТЭГЭЭД чингээд, ингээд; *эхлээд өөрөө сур, тэгээд бусдыг сурга; энэ ажлыг тэгээд хий!*

ТЭД тэр гэдэг үгийн олон тооны хэлбэр, хол байгаа юмыг бусдын зүг зааж хэлэлцэхэд хэрэглэнэ; *тэд ирэх үү? тэднээр юу хийлгэх вэ? би тэдэнтэй хамт явна; чи тэднийг дагуулаад ууланд явах хэрэгтэй.*

ТЭДГЭЭР биеэс холхон байгаа олон юмыг заах үг; *тэдгээр хүн; тэдгээр мал.*

ТЭДНИЙХ тэд гэж хамаадуулан заах утга; *энэ хураасан өвс тэднийх үү? тэднийх хаа буусан бэ?*

ТЭДЭН тэд гэж заах үг, нэрлэхээс бусад тийн ялгалын дагавартай орох үндэс; *энэ хэсэг адуу тэдний адуу мөн байна; би тэднийд очив; тэднийг цөмий нь аваад ир!*

ТЭЖГЭР хүн амьтны ус буюу өвс ургамлын нимгэн тачир; *тэжгэр үстэй; тэжгэр өвстэй.*

ТЭЖЭЭВЭР хүний тэжээж ашиглах гэрийн амьтан; *тэжээвэр нохой; тэжээвэр шувуу; тэжээвэр мал; тэжээвэр нугас; тэжээврийн амьтан;* **тэжээвэр хүүхэд** (үрчилж хүмүүжүүлсэн өргөмөл хүүхэд).

ТЭЖЭЭГДЭХ тэжээхийн үйлдэгдэх хэв.

ТЭЖЭЭГЧ тэжээж тэтгэдэг этгээд; *шувуу тэжээгч; гахай тэжээгч.*

ТЭЖЭЭЛ хүн малын идэшний зүйл; **хүнс тэжээл, идэш тэжээл** хор ш.; *бордоо тэжээл; өвсөн тэжээл; сүүн тэжээл; гахайн тэжээл; морины тэжээл; тэжээлийн бааз; тэжээлийн морь; тэжээлийн газар; тэжээлийн манжин.*

ТЭЖЭЭЛГЭХ 1. тэжээхийн үйлдүүлэх хэв; 2. тэжээгдэх.

ТЭЖЭЭЛЧ аливаа амьтныг тэжээх үүрэг хүлээсэн хүн; *тэжээлч өвгөн.*

ТЭЖЭЭХ 1. аливаа амьтанд идэш хоол өгөх зэргээр тэтгэж амьдруулах; *сүүгээр тэжээх; өвсөөр тэжээх; овёсоор тэжээх; тэжээж өсгөх; тэжээсэн бяруу тэрэг эвдэх* зүйр; **гэдэс тэжээх, амь тэжээх** (аж төрж амьдрах); 2. хүнийг хүмүүжүүлэн аж төрүүлэх ба тэтгэх; **тэжээх тэтгэх** хор ш.; **тэжээсэн эцэг эх** (үрчилсэн эцэг эх).

ТЭЛИЙХ хазайх, далжийх.

ТЭЛМЭН: тэлмэн жороо, усан тэлмэн жороо ёстой жороо; гайхамшигтай жороо; *тэлмэн жороо морьтой л гэнэ.*

ТЭЛРҮҮЛЭХ тэлрэхийн үйлдүүлэх хэв.

ТЭЛРЭХ ухаан орох, сэргэх, сэхэх.

ТЭЛҮҮ (Н) уужуу, тавиу, арай том, арай ихээхэн, тэнүүн, уужим; *тэлүү хашаа; тэлүү хороо; тэлүү газар; тэлүү зайтай.*

ТЭЛҮҮЛЭХ I аливаа амьтны хорьсон, барьсан, уясан зэргээс гарч явахыг завдалхийлан тэмүүлэх, зүтгэх.

ТЭЛҮҮЛЭХ II тэлэхийн үйлдүүлэх хэв; 2. тэлэгдэх.

ТЭЛҮҮР юмыг тэлэхэд зориулж хийсэн хэрэглэл; *тэлүүр мод.*

ТЭЛҮҮРДҮҮЛЭХ 1. тэлүүрдэхийн үйлдүүлэх хэв; 2. тэлүүрдэгдэх.

ТЭЛҮҮРДЭГДЭХ тэлүүрдэхийн үйлдэгдэх хэв.

ТЭЛҮҮРДЭХ юмыг тэлүүрт тэлэх; *хувцас тэлүүрдэх; арьс шир тэлүүрдэх.*

ТЭЛЧИГНҮҮЛЭХ тэлчигнэхийн үйлдүүлэх хэв.

ТЭЛЧИГНЭХ тэлчлэх, тийчлэх.

ТЭЛЧЛҮҮЛЭХ тэлчлэхийн үйлдүүлэх хэв.

ТЭЛЧЛЭХ хүн амьтны бие мөчөөр тийчлэн хөдлөх, тийчлэх; *хөлөөрөө тэлчлэх; тэлчилж байгаад хучлагаа сандаачихжээ.*

ТЭЛЧЭЭ тийчлээ, тэлчлэмтгий.

ТЭЛЭГДЭХ тэлэхийн үйлдэгдэх хэв.

ТЭЛЭХ I 1. арьс, бөс, эсгий зэргийг жийгнүүлэн цовтолж татах; *арьс тэлэх; эсгий тэлэх; дээл тэлэх; зураг тэлж өлгөх;* 2. мөрөн голын ус асар их болж савнаасаа бялхаж халих; *ус тэлэх; гол тэлэх;* 3. өвчин тахал, яр шарх зэргийн түгж дэлгэрэх, их болох; *шарх тэлэх; тахал тэлэх.*

ТЭЛЭХ II хурга, ишиг зэргийг хоёр эхэд хөхүүлэх; *хурга тэлэх; тугал тэлэх.*

ТЭЛЭЭ I өмд тогтоож уях оосор; *өмдний тэлээ.*

ТЭЛЭЭ II хоёр эхийн дунд тэжээгдсэн төл мал; *тэлээ хурга; тэлээ тугал.*

ТЭЛЭЭЛҮҮЛЭХ тэлээлэхийн үйлдүүлэх хэв.

ТЭЛЭЭЛЭХ I өмдийг тэлээгээр тогтоож торгох; *өмд тэлээлэх.*

ТЭЛЭЭЛЭХ II малын төлийг хоёр эхэд хөхүүлэх.

ТЭЛЭЭС тэлэх үйлийн нэр; *тэлээс сайтай; тэлээс муутай; тэлээс нь чангаджээ.*

ТЭМБҮҮ: тэмбүү яр өнгөний халдварт яр өвчин, зан яр ч гэдэг; **яр тэмбүү** х о р ш..

ТЭМБҮҮРҮҮЛЭХ тэмбүүрэхийн үйлдүүлэх хэв.

ТЭМБҮҮРЭХ тэмбүү өвчин тохиолдох.

ТЭМДЭГ 1. засаг төр, олон нийтийн байгууллагын албан хэрэгт дарах зөвхөн оноосон нэртэй сүлдгүй захирлага; **тамга тэмдэг** х о р ш.; *лацны тэмдэг; нуцын тэмдэг; тэмдэг дарах;* 2. мал ба эд хогшил зэрэгт таних гэрч болгож хийсэн зүйл; *саран тэмдэг; чандмань тэмдэг; тоон тэмдэг; үсэг тэмдэг; таних тэмдэг; тэмдэг тавих;* **мутрын тэмдэг** (эрхэм дээд хүмүүсийн ямар нэгэн хэрэгт үзсэн мэдсэний гэрч болгож дарах тэмдэг); **им тэмдэг** (а. малын чих зэрэгт хийсэн таних тэмдэг; б. амьтны төмс засаа); ☆ **одон тэмдэг** (улс нийгэмд гавьяа зүтгэл гаргасдад улсын дээд эрх барих газраас шагнаж олгох тусгай тэмдэг); **энгэрийн тэмдэг** (ямар нэгэн учир, энгэртээ зүүхэд зориулсан тэмдэг); **сарын тэмдэг** (эмэгтэйчүүдийн сар сард тогтмол үздэг юм); **шинж тэмдэг** (юмны онцгой шинж байдал); **билэг тэмдэг** (юмны өвөрмөц онцгой байдал); **гар тэмдэг** (зөвхөн өөрөө мэдэх төдий тэмдэглэл); **гарын тэмдэг** (гарын үсгийн оронд хэрэглэх тэмдэг); **нэрийн тэмдэг** (зөвхөн нэр нь бүхий тэмдэг); **эрхийн тэмдэг** (хүний зэрэг тушаал, эрх үүргийн ялгаж таних тэмдэг); **ёр тэмдэг** (зөгнөлийн үр боловсрол гэж үзсэн юм); **сэжиг тэмдэг** (ямар нэгэн ажиг дарж мэдсэн, таамнасан зүйл); **өдрийн тэмдэг** (албан бичгийн ирсэн, явуулсан сар өдөр зэргийг бүртгэн тэмдэглэх данс); **үүрийн тэмдэг** (үүр гэгээрэхийн урьдхан дорно зүгээс гийх шар гэгээ); **тэмдэг мэдэгдэх** (ямар нэгэн юмны онцлог шинж байдал нь илрэгдэх, илрэхэд хүрүүлэх); **тэмдгийн нэр** (юмны билэг чанарыг заасан нэр).

ТЭМДЭГЛҮҮЛЭХ 1. тэмдэглэхийн үйлдүүлэх хэв; 2. тэмдэглэгдэх.

ТЭМДЭГЛЭГДЭХ тэмдэглэхийн үйлдэгдэх хэв.

ТЭМДЭГЛЭГЧ аливаа зүйлийг данс бичигт бичих ба юманд тусгай тэмдгээр тэмдэглэх хүн; *цаг уурын тэмдэглэгч.*

ТЭМДЭГЛЭЛ аливаа хэрэг явдлыг тэмдэглэн бичсэн бичиг дэвтэр; *өдрийн тэмдэглэл; хувийн тэмдэглэл; тэмдэглэлийн дэвтэр; нэрсийн тэмдэглэл; замын тэмдэглэл.*

ТЭМДЭГЛЭЛТ тэмдэглэвэл зохих юм; *тэмдэглэлт өдөр.*

ТЭМДЭГЛЭЛТЭЙ тэмдэглэвэл зохих зүйл бүхий.

ТЭМДЭГЛЭХ 1. юманд тэмдэг хийх, тэмдэг тавих; *мал тэмдэглэх; эд хогшил тэмдэглэх;* 2. юмыг данс бичигт бичих; **бичих тэмдэглэх** х о р ш.; *дансанд тэмдэглэх;* 3. ямар нэгэн үйл явдлыг зааж илэрхийлэх; *Октябрийн баярыг тэмдэглэх; Сүхбаатарын мэндэлсний ойг тэмдэглэн өнгөрүүлэв.*

ТЭМДЭГТ 1. тэмдэг бүхий юм; 2. улсын цаасан мөнгө, зоос; 3. худалдаа, гайль татварын тухай тусгайлан олгосон бичиг баримт; *худалдааны тэмдэгт; гайлийн тэмдэгт; тэмдэгтийн татвар;* **тэмдэгт бичиг** (үнэмлэх гэрч болгож тамга тэмдэг дарах буюу гарын үсэг зурж олгосон баримт бичиг).

ТЭМДЭГТЭЙ тэмдэг бүхий.

ТЭМНҮҮР хөл уурын түшүүр хөндлөн мод.

ТЭМТРҮҮЛ хорхой шавьж зэрэг амьтанд их төлөв амны этгээдэд байх хүртэхүй эрхтэн; *ямаан хорхойн тэмтрүүл; аалзны тэмтрүүл.*

ТЭМТРҮҮЛЭХ 1. тэмтрэхийн үйлдүүлэх хэв; 2. тэмтрэгдэх.

ТЭМТРЭГДЭХ тэмтрэхийн үйлдэгдэх хэв.

ТЭМТРЭХ сохор амьтан буюу нүдтэй боловч үл харагдах юм хумыг эрж гар хөл буюу тэмтрүүл мэтээр турших; **хүйс тэмтрэх** (амьтныг гэр орноор, удам агсаагаар, ай сүргээр, хэсэг бүлгээр нь үлдээлгүй хядах).

ТЭМТЧИХ байн байн тэмтрэх; *тэмтчиж яваад юу хийнэ, гэртээ сууж бай.*

ТЭМТЧҮҮЛЭХ тэмтчихийн үйлдүүлэх хэв.

ТЭМТЭРХИЙЛЭХ тэмтрэн тэмтчих.

ТЭМҮҮЛҮҮЛЭХ тэмүүлэхийн үйлдүүлэх хэв.

ТЭМҮҮЛЭХ ямар нэгэн үйл явдалд хүсэн дурлаж, тогтон ядаж зүтгэлхийлэх; *хөдөө явах гэж тэмүүлэх; гадаадад явах гэж тэмүүлэх; хоол идэх гэж тэмүүлэх; уяа хүлээгээ тайлуулах гэж тэмүүлэх; цэрэгт явах гэж тэмүүлэх; жолооч болох гэж тэмүүлэх.*

ТЭМЦҮҮЛЭХ тэмцэхийн үйлдүүлэх хэв.

ТЭМЦЭГЧ тэмцдэг этгээд; *ард түмний төлөө тэмцэгч; баатарлаг тэмцэгч.*

ТЭМЦЭЛ аливаа үйл хэргийг булаалдан мэтгэлдэх, тэмцэлдэх үйлийн нэр; **атаа тэмцэл** х о р ш.; тэмцэл хийх; ангийн тэмцэл; амьдралын тэмцэл; *нийгэм журмын төлөө тэмцэл; энх тайвны төлөө тэмцэл; үзэл суртлын тэмцэл.*

ТЭМЦЭЛДҮҮЛЭХ тэмцэлдэхийн үйлдүүлэх хэв.

ТЭМЦЭЛДЭХ тэмцэхийн үйлдэлдэх хэв.

ТЭМЦЭЛЦЭХ тэмцэхийн үйлдэлцэх хэв.

ТЭМЦЭХ 1. үйл хэргийн төлөө хоёр тал болж харилцан маргах, булаалдах, эсэргүүцэх, мэтгэлцэх зэргээр тэмцэл хийх; *эрх чөлөөний төлөө тэмцэх; сайн сайхан амьдралын төлөө тэмцэх; үг үгэа булаалдан тэмцэх; хүч чадлаа тэнсэж тэмцэх;* 2. машид хүслэн болох; тэмүүлэх; *гэрийн зүг тэмцэх;* ☆ **амь тэмцэх** (амьсгал цухалдах).

ТЭМЦЭЭН тэмцэх, тэмцэлдэх үйлийн нэр; **уралдаан тэмцээн, маргаан тэмцээн; сорилт тэмцээн** х о р ш.; *буудлагын тэмцээн; спортын тэмцээн; онолын тэмцээн; шатрын тэмцээн.*

ТЭМЭЭ (Н) нуруундаа нэг буюу хоёр **бөхтэй**, хивдэг том амьтан, бие өндөр болоод **хүзүү** гагагар, *атан тэмээ; ганц бөхтэй тэмээ; тэмээн жин; тэмээн сүрэг; тэмээний ноос;* **тэмээ гэхэд ямаа гэх** (буруу зөрүү ярих); *тэмээ хариулсан хүн буурынхаа занг андахгүй* з үй р; **тэмээний хөх** у р г а м а л (зэрлэг гаймуу ногооны адил, чавга мэт цоморлогтой, идэж болно); **тэмээн гөрөөс** а м ь т а н (хоёр бөхт зэрлэг тэмээ, хавтгай ч гэдэг, маш ховордсон амьтан); **тэмээлжин хяруул** а м ь т а н (явган шувууны төрөл, одоо цагт бүх шувууны дотроос хамгийн том нь, гүйх нь хурдан, зарим газарт тэжээж өсгөх нь бий, өд нь их үнэ хүрнэ, мах ба өндгий нь иднэ); **тэмээний хоолой у р г а м а л** (иш өндөр болоод хонгилтой, навчиндаа сондуутай, борлуулж иднэ, бас ч исгэлэн ус ч хийх нь бий); **тэмээн сүүл у р-**

г а м а л (харганын төрөлд багтдаг сөөг ургамал, ойн бүсээс дээш уулын оройд ургадаг, мал төдий л иддэггүй); **тэмээн харгана** у р г а м а л (1,5—2 метр өндөр, мөчир салаалсан, шар ногоон хальстай, хос хосоор ургадаг өдлөг навчтай, сөөгөрхөг ургамал); **тэмээн хэл** у р г а м а л (20—30 см. өндөр, олон наст ургамал, том бөгөөд уртавтар гонзгой навчтай, цэцгийн өнгө тунгалаг ягаан, бас шар өнгөтэй ч бий).

ТЭМЭЭЖИХ тэмээ олонтой болох.

ТЭМЭЭЖҮҮЛЭХ тэмээжихийн үйлдүүлэх хэв.

ТЭМЭЭЛЗГЭНЭ а м ь т а н хүзүү ба бие урт, хэвэл их, жигүүртэй, бусад хорхойг барьж дэг шавьж, үүнийг тэмээлзгэнэ царцаахай, тэмээлзгэнэ хорхой гэж нэрлэх нь бий.

ТЭМЭЭЧ (ИН) тэмээ адуулагч.

ТЭН тэмээ малд тэнцүүлж ачих ачааны нэг талд ачихаар тааруулан хийсэн ачаа; *тэн хийх; тэн тэнцүүлэх;* **тэн адил** (хүнд хөнгөн, их бага нь яг адил); **тэн хуваах** (хувь адил болгож хуваах); **тэн татах** (гэр, майхан зэргийг салхи шуурганаас болгоомжлон бэхэлж оосроор даруулан уяж торгох); **тэн сацуу, тэн чацуу** (яг сацуу, яг адил); **тэн хагас** (яг тал хувь нь); **тэнгийн мод** (жинлүүр, цэнлүүр, жин дэнс зэргийн нуруу мод, бас годил ч гэдэг).

ТЭНГҮЙ юмны хирээс хэтэрхий, тэнцэх аргагүй; *тэнгүй хүчтэй хүн; тэнгүй том биетэй.*

ТЭНГЭР 1. огторгуй, газрын дээд талд бий бидний нүднээ үзэгдэх агаар мандал; *хөх тэнгэр; агаар тэнгэр; тэнгэр бүрхэх; тэнгэр муухай аашлах; тэнгэр дулаарах; тэнгэр хүйтрэх;* тэнгэр арилах (үүл хур арилах); **тэнгэр үүлтэх**, тэнгэр үүлсэх (тэнгэрт үүл бий болох); тэнгэр бүрхэх (агаарт үүл хурах); **тэнгэр бүүдийх** (агаар цэлмэг биш болох); **тэнгэр гийх** (тэнгэр цэлмэг болох шинж орох); тэнгэр хаяарах (тэнгэрийн захаас үүл сийрэх); тэнгэр **задрах** (тэнгэрийн байдал ая тавгүй болох); **тэнгэр зохирох** (тэнгэрийн байдал аятай болох); **тэнгэр хуйсганах**, **тэнгэр хуйсрах** (тэнгэрийн байдал ая муутай, тохиромжгүй болох); **тэнгэр ниргэх** (аянга ниргэх): тэнгэр дуугарах (цахилгаан тэсрэлтийн дуу гарах); **тэнгэр хүйтрэх** (тэнгэрийн байдал хүйтэн болох шинж орох); **тэнгэр цэлмэх** (бүрхэг байсан тэнгэр цэлмэг болох); **тэнгэр дулаарах** (тэнгэрийн байдал дулаан, тогтиун болох); **тэнгэрийн өнгө (а, хөх цэнхэр өнгө;** б. тэнгэрийн байдал); **тэнгэрийн хаяа, тэнгэрийн хормой** (үзэгдэх агаарын зах); **тэнгэрийн оёдол, тэнгэрийн заадал** (шөнө үзэгдэх огторгуйн гол мэт цагаавтар ягц бяцхан одоод); **тэнгэрийн өрой** (хянагч этгээдийн харааны зүгт эгц дээш орших агаар мандлын хамгийн алсын цэг); **тэнгэрийн дуу** (аянга цахилгаан тэсрэлтийн дуу); 2. бөө нарын шүтэх шүтээн; *зүүн дөчин дөрөөн тэнгэр ээ; Дөрөө галивар ноён, барууи тавин таван тэнгэр ээ! таван их хаалга үүд* [бөөгийн дуудлага]; **муу зүгийн тэнгэр, хар зүгийн тэнгэр** х у у ч и р с а н (бөөгийн ёсонд; хүнд муу, хорлолтой бүхнийг хийдэг тэнгэр, онгод); **сайн зүгийн тэнгэр, цагаан зүгийн тэнгэр** х у у ч и р с а н (бөөгийн ёсонд; хүнд сайн, тустай бүхнийг хийдэг тэнгэр, онгод); **тэнгэр мэдэг** (үйл ажлын ямар болохыг хувь заяа мэд гэж даатган итгэх нь); ☆ **тэнгэрийн хөвгүүн** х у у ч и р с а н (хааныг өргөмжлөн нэрлэх нэр); **тэнгэрийн ван** з у р х а й (уран); **тэнгэрийн дүлий** у р г а м а л (чийгтэй газар ургадаг, битүү хальс бүрхүүлтэй мөөг мэт ургамал, төрөл зүйл нэг мянга орчим, эмнэлэгт хэрэглэх нь бас бий).

ТЭНГЭС дэлхийн усан бүрхэвчийн нэгэн хэсэг нь болох давстай шивтэр амттай асар их ус; *Хар тэнгэс; тэнгэсийн цэрэг; тэнгэсийн явган цэрэг.*

ТЭНГЭСЧ 1. тэнгэсийн цэргийн албан хаагч; 2. тэнгэст аялан явагч.

ТЭНГЭЦҮҮЛ тэнгэцүүлэх юм.

ТЭНГЭЦҮҮЛЭХ тэнгэцэхийн үйлдүүлэх хэв.

ТЭНГЭЦЭЛ тэнгэцсэн нь.

ТЭНГЭЦЭЛГҮЙ үл тэнгэцэх.

ТЭНГЭЦЭХ 1. таарах, тохирох; *уралдаанд тэнгэцэх дугуй;* **нас тэнгэцэх** (тогтоосон юманд нас тохирох; *цэргийн албанд нас тэнгэцэх);* 2. тэнцэх.

ТЭНД энд биш гэж нөгөө хол зайтай байгаа юмыг заан хэлэлцэхэд хэрэглэх үг; *манай гэр тэндээс холгүй; тэндээ нэг их удаад яах вэ дээ;* **энд тэнд** (хол ойр); **энд тэндгүй** (хаяагүй); **энд тэндээс** (хол ойроос).

ТЭНДЭХ тэр газрынх, тэр газар дахь; *тэндэх хүмүүсийн зан ааш их сайн; тэндэхийн ургац эндэхээс илүү.*

ТЭНЖЭЭ ачаа тэгнэх оосор; *тэнжээ олс; тэнжээ сур.*

ТЭНИЙЛГЭХ тэнийхийн үйлдүүлэх хэв; *төмөр утас тэнийлгэх; арьс шир тэнийлгэх; уе мөчөө тэнийлгэх; нуруугаа тэнийлгэх.*

ТЭНИЙХ 1. тэнэгэр болох; *нүүр тэнийх; утас тэнийх; хөл тэнийх; гар тэнийх; арьс тэнийх;* 2. санаа сэтгэл сэргэх; *сэтгэл тэнийх.*

ТЭНСҮҮЛЭХ 1. тэнсэхийн үйлдүүлэх хэв; 2. тэнсэгдэх.

ТЭНСЭГДЭХ тэнсэхийн үйлдэгдэх хэв.

ТЭНСЭЛХИЙЛЭХ туршин тэнсэж үзэх; *байдлы нь тэнсэлхийлэх.*

ТЭНСЭХ 1. юмны үнэн ташаа, сайн муу зэргийг сорьж сунган үзэх; *чадлаа тэнсэх;* 2. үйл хэргийг хянаж турших; *тэнсэх ял шийтгэх; тэнсэх турших хэрэг юү вэ.*

ТЭНТГЭР бие маш бүдүүн махлаг; *тэнтгэр таргаи шар; тэнтгэр махлаг хүүхэд.*

ТЭНТИЙЛГЭХ тэнтийхийн үйлдүүлэх хэв.

ТЭНДИЙХ тэнтгэр болох.

ТЭНТЭГНҮҮЛЭХ тэнтэгнэхийн үйлдүүлэх хэв.

ТЭНТЭГНЭХ тэнтгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ТЭНТЭЛЗҮҮЛЭХ тэнтэлзэхийн үйлдүүлэх хэв.

ТЭНТЭЛЗЭХ тэнтгэр юмны байн байн хөдлөх.

ТЭНТЭР: тэнтэр тунтар хийх явахдаа дэм олохгүй хөдлөх, явах, энд тэнд гишиглэх.

ТЭНҮҮЛ тэнэж явсан нь, тэнэмэл; **тэнүүл зайгуул** х о р ш.; *тэнүүл хүн; тэнүүл мал; тэнүүл бадарчин.*

ТЭНҮҮЛЧ хэсүүлч, тэнэдэг зантай хүн.

ТЭНҮҮЛЭХ тэнэхийн үйлдүүлэх хэв.

ТЭНҮҮН 1. хүн амьтны бие тавиу сайхан; *сэтгэл тэнүүн байна; тэнүүн хүн;* 2. цаг улирлын дулаан тогтиуи сайхан байхы нь; *тэнүүн өдөр гадуур явахад зохимжтой.*

ТЭНҮҮЧЛҮҮЛЭХ тэнүүчлэхийн үйлдүүлэх хэв.

ТЭНҮҮЧЛЭХ хүний дэмий хэсүүчилж явах.

ТЭНХЖИХ гэнхэх, тэнхрэх.

ТЭНХЛҮҮН хөгширч насжисан боловч тийм их дордож доройтоогүйгий нь; *тэнхлүүн өвгөн байна билээ.*

ТЭНХЛЭГ 1. тэрэгний арлыг госсон булны нүхэнд дүрэх хөндлөн төмөр буюу мод; *тэрэгний тэнхлэг;* 2. хөгжмийн чавхдасыг чангаруулах хуруу мэт зүйл; *хөгжмийн тэнхлэг;* 3. ямар нэгэн биеийн голд чиг болон орших шулуун; гулд зүйл; *дэлхийн тэнхлэг.*

ТЭНХМЭЛ тэнэмхий, хэрцгий муу хүн; *тэнхмэл хүн хэцүү шүү.*

ТЭНХРҮҮЛЭХ тэнхрэхийн үйлдүүлэх хэв.

ТЭНХРЭХ 1. ухаан мэдрэл алдан унаж муужирсан хүн сэхэж сэргэх; 2. хүн амьтны гачигдсан, мухардсан, доройтсон нь сэхэж дээрдэн дээшлэх.

ТЭНХЭГ тэнхээтэй; *тэнхэг хүн.*

ТЭНХЭЛ тамир тэнхээ; *тэнхэл сайтай; тэнхэл муутай.*

ТЭНХЭХ тэнхрэх, тэнхжих.

ТЭНХЭЭ хүн амьтны биед бүхий бяр чадал; **чадал тэнхээ, тамир тэнхээ** х о р ш.; *тэнхээ алдрах; тэнхээ тасрах; тэнхээ барах; тэнхээ муудах; тэнхээ доройтох; тэнхээ орох; бие тэнхээ чинь ямар байна?*

ТЭНХЭЭГҮЙ чадал тамиргүй, чадал тамир муутай.

ТЭНХЭЭДҮҮЛЭХ тэнхээдэхийн үйлдүүлэх хэв.

ТЭНХЭЭДЭХ 1. чадал тэнхээ үлэмж хэрэгсэх; *хүндийг өргөх гэж нилээд тэнхээдэв шүү;* 2. чадал тэнхээ доройтох; *өвдсөнөөс хойш бүр тэнхээдэж орхижээ.*

ТЭНХЭЭЖИХ чадал тэнхээ орж нэмэгдэх.

ТЭНХЭЭЖҮҮЛЭХ тэнхээжихийн үйлдүүлэх хэв.

ТЭНХЭЭТЭЙ тэнхээ бүхий, чадал тэнхээ ихтэй, тамир сайтай, бяр чадалтай; *тэнхээтэй эр; тэнхээтэй морь; тэнхээтэй машин.*

ТЭНЦВЭР тэнцээр.

ТЭНЦВЭРГҮЙ тэнцээргүй.

ТЭНЦВЭРТЭЙ тэнцээртэй.

ТЭНЦҮҮ нэг адил; *тоо тэнцүү; хүнд хөнгөн тэнцүү; их бага нь тэнцүү; тэн тэнцүү.*

ТЭНЦҮҮЛЭХ тэнцэхийн үйлдүүлэх хэв, тэнцүү болгох.

ТЭНЦҮҮР харилцан тохирох, зохицох, тэнцээр; *утсан дээр тэнцүү хийх.*

ТЭНЦҮҮРГҮЙ 1. тэнцэшгүй; 2. харилцан адилгүй.

ТЭНЦЭХ 1. юмны хүч, хир хэмжээ харилцан тохирох; *ажилд тэнцэх; цэргийн нас тэнцэх; сургуульд тэнцэх; чадвар тэнцэх; хүч тэнцэх;* **тэнцэх тэмдэг** (тэнцүү болохыг илэрхийлсэн (=) тэмдэг).

ТЭНЦЭЭР тэнцэх, тохирох нь тэнцвэр, тэнцүүр; *их багын тэнцээр ямар байна? тэнцээр муутай; тэнцээр сайтай.*

ТЭНЦЭЭРГҮЙ тэнцүүргүй, тэнцвэргүй, тэнцээр муутай, тэнцэж тохироогүй

ТЭНЦЭЭРТЭЙ тэнцүүртэй, тэнцвэртэй, тэнцээр сайтай; тэнцэж тохирсон нь.

ТЭНЧРЭХ хүн амьтны аливаа үйл явдалд их л зовнин мэндүүрэх.

ТЭНЧҮҮРЭХ тэнчрэхийн үйлдүүлэх хэв.

ТЭНШИХ 1. гайхалтай юмыг үзэж хэл тагнайгаа шаг шаг дуугаргах; 2. хүний хэсч тэнэн эрэх; 3. юмыг савдах.

ТЭНЭГ ухаан мэдрэл мохдог дорой; **тэнэг мохоо, тэнэг дүйнгэ** хорш.: *тэнэг толгой, хөлийн дайсан* зүйр; *тэнэг сэцэн хоёр хөврөлдөж чадахгүй, тэмээ ямаа хоёр мөргөлдөж чадахгүй* зүйр; **тэнэг түрүү** (хонь малын хошгиногийн бүдүүн үзүүрийн үсгүй арьс, алганаг ч гэдэг); **тэнэг өвс** ургамал (өндөр нь 40—50 см., хатангир хуурай иш мөчиртэй, жижиг цайвар навчтай, хөвөн хэлбэрийн үртэй ургамал, говь цөлийн бүсэд ургана, нялх мөчрийг бог мал сайн иднэ).

ТЭНЭГДҮҮ тэнэг байдалтай.

ТЭНЭГДЭХ хэтэрхий тэнэг болох.

ТЭНЭГЛҮҮЛЭХ тэнэглэхийн үйлдүүлэх хэв.

ТЭНЭГЛЭХ тэнэг байдал гаргах; *чи битгий тэнэглээд бай.*

ТЭНЭГЛЭХ тэнэгдэх, тэнэг болох.

ТЭНЭГТЭХ тэнэг зан байдал гаргах.

ТЭНЭГХЭН нилээд тэнэг, баахан тэнэг.

ТЭНЭГЭР I нэгэн зүйл чулуу; **хас тэнэгэр** хорш.; тэнэгэр мод ургамал (иш маш шудрага, өндөр нь хос алд илүү нэг зүйл мод).

ТЭНЭГЭР II муруйсан атирсан, нугаларсан үрчийсэнгүй шулуун толигор юм; *тэнэгэр арьс; тэнэгэр даавуу;* 2. шилжсэн санаа сэтгэлийн зовнисон, бухимдсан явдалгүй амар тавиун, *сэтгэл тэнэгэр.*

ТЭНЭМГИЙ тэнэмхий.

ТЭНЭМХИЙ тэнэдэг, хэсдэг зантай хүн, тэнэмгий; *тэнэмхий хүн.*

ТЭНЭМЭЛ дэмий хэсүүчлэх хүн амьтан; *тэнэмэл бадарчин; тэнэмэл бух.*

ТЭНЭХ дэмий хэсч хэрэн явах; *дэмий тэнэх; хэсэх; тэнэх; тэнэх доншуучлах; тэнэх төөрөх.*

ТЭР хол байгаа юм заах үг; **энэ тэр** хорш.; *тэр ийн хэлрүүн ... тэр л биз; тэр хүн; тэр жил; тэр үед; тэр хир би завгүй байлаа; тэр мэт; тэр ч байтугай;* **тэртэй тэргүй** (ямар ч байсан); **тэр даруй** (тэр дороо, даруйд); **тэр тушаа** (тэр хавь, тэр орчимд); **тэр хир** (а. тэр тухай; б. түүнийх зөв; в. юмны хир хэмжээндээ зохицож таарсны нь); **энэ тэр** (гэх мэт; *ном дэвтэр энэ тэр чинь яалаа?*).

ТЭРБУМ арван оронтой тооны нэр.

ТЭРГҮҮЛЭГЧ ямар нэгэн юмыг толгойлон удирдах хүн; *өрхийн тэргүүлэгч; хурлын тэргүүлэгч; засгийн газрын тэргүүлэгч; тэргүүлэгч гишүүн;* **тэргүүлэгч цэцэг** ургамал (иш богино, ац салаа хөндлөн тиш тохойлон ургасан бөгөөд найлзуурын дурс ногоон, навч гүйлсний навчтай адил болоод үзүүр шуумгай, цэцэг таван хэлтэстэй, үнэр сайхан, аливаа цэцгээс урьд цэцэглэдэг цэцэг).

ТЭРГҮҮЛЭГЧИД олон тэргүүлэгч; *их хурлын тэргүүлэгчид;*

ТЭРГҮҮЛЭХ 1. тэргүүн болох, даргалах, манлайлах, толгойлох; *гэр тэргүүлэх; тэргүүлэх тушаал;* 2. түрүүлэх, хушуучлах.

ТЭРГҮҮН 1. толгой; **толгой тэргүүн** хорш.; 2. толгойлогч, удирдагч, ерөнхийлөгч; *засгийн газрын тэргүүн; төлөөлөгчдийн тэргүүн;* **тэргүүн захас** (тэргүүлж даргалсан хүн); **тэргүүн сайд** (жинхэнэ сайд); 3. хуучирсан нэгдүгээр зэрэг шагнагдсан тайж; *тэргүүн зэрэг;* 4. юмны дээд тал, урд тал; **тэргүүний залуур** (онгоцны хэрэгсэл); 5. нэгдүгээр, анхдугаар, анхны, эхний; *тэргүүн дэвтэр; тэргүүн боть.*

ТЭРГҮҮР олны зорчих их зам; **зам тэргүүр** хорш..

ТЭРГҮҮТЭН нэрэлсэн юм тэргүүтэй; *Сухбаатар тэргүүтэн Ардын Намын нөхөд; нэгд-*

лийн дарга тэргүүтэн хэд хэдэн гишүүн манай бригадын байранд ирэв; алт тэргүүтэн бусад үнэт зүйлс.

ТЭРГЭЛ: **тэргэл сар** дүгрэг үзэгдэх сар; **тэргэл өдөр** (сар дүгрэглэх өдөр); **тэргэл од** (Долоон Өвгөн гэдэг одны орд).

ТЭРИЙЛГЭХ тэрийхийн үйлдүүлэх хэв.

ТЭРИЙХ тарайх; *тэрийж унах; тэрийж хэвтэх; тэрийн ойчих.*

ТЭРЛҮҮЛЭХ 1. тэрлэхийн үйлдүүлэх хэв; 2. тэрлэгдэх.

ТЭРЛЭГ зуны дээл; *эрээн даавуу дотортой хөх чимүү тэрлэг.*

ТЭРЛЭГДЭХ тэрлэхийн үйлдэгдэх хэв.

ТЭРЛЭХ 1. бүрэлдэж бүтэх, бүрэлдэн биелэх, биеийн дүрсийг олох; *эхийн умайд сая тэрлэж бүхий үр;* 2. ш и л ж с э н хийх юм төлөв гүйцэх; *би ч ажлаа тэрлэж байна.*

ТЭРМЭ (Н) нэгэн зүйл ноосон бараа; **цэмбэ тэрмэ** *х о р ш.*; *нэг дугуй тэрмэ; тэрмэн дээл;* ☆ **гэрмэн нугас** (боржин нугас).

ТЭРС 1. тэрсүүд, гажуу; *тэрс хүн;* **тэрс ном** (аливаа шашинд харш ном); **тэрс номтон** (тэрс ном, харш сургаал баримтлагчид); 2. зөрүүд, эсрэг, сөргүү; **тэрс загнах** (гажуу зан гаргах); **эсрэг тэрс** (гаж буруу, **зөрүүд**); **тэрс этгээд** (ёс зүйг дагахгүй сөрж явах этгээд).

ТЭРСДЭХ хэтэрхий тэрс болох.

ТЭРСЛҮҮ тэрс, эсрэг, зөрүү; *тэрслүү явдал; тэрслүү зан.*

ТЭРСЛҮҮЛЭХ тэрслэхийн үйлдүүлэх хэв.

ТЭРСЛЭХ гажуу тэрс үйл явдал хийх, үйлдэх, тийм зан байдал гаргах; **эсэргүүцэх тэрслэх, урвах тэрслэх** *х о р ш.*; *чи урдаас битгий тэрсэлж бай; улс төрд тэрслэх*

ТЭРСҮҮД гажууд, зөрүүд; *тэрсүүд зан гаргах.*

ТЭРТЭЭ 1. тэр талд, нөгөө этгээдэд; *голын тэртээ; байшингийн тэртээ талд;* 2. зайтай, хол; *тэртээ тэнд байгаа юманд хүрэх.*

ТЭРТЭЭХ тэртээ талд бүхий, цаадахь; *уулын тэртээх; усны тэртээх айл; хилийн тэртээх аймаг улс.*

ТЭРҮҮ (Н) түүн; *тэрүүний; тэрүүнд; тэрүүнээс.*

ТЭРҮҮГЭЭР тар талаар, нөгөө талаар, цаагуур, түүгээр; *тэрүүгээр явагтун; тэрүүгээр явахад тун тойруу байдаг юм.*

ТЭРҮҮХЭН тэрхэн; *чи тэрүүхэн тэнд зогсож бай, чиний зургийг авна.*

ТЭРХҮҮ мөн, тэр; *тэрхүү хүн бас дахин ирэв.*

ТЭРХЭН тэр өчүүхэн зайд, тэр баахан хугацаанд, тэр хавьханд; *тэрхэн зуур; тэрхэн үе; тэрхэн газар; тэрхэн цагт.*

ТЭРЭГ (ТЭРГЭН) 1. суух ачихад зориулсан арал, дугуйтай, морь үхэр тэмээ зэрэгт хөллөх хэрэгсэл; **тэрэг чарга** *х о р ш.*; *морин тэрэг; үхэр тэрэг; тэмээн тэрэг; тэрэг түлээ; нэг тэрэг ачаа;* **төмөр тэрэг** (дугуйны мөөрийг төмрөөр бэхэлсэн тэрэг); **хүүхдийн тэрэг** (нялх хүүхдийг авч явах бяцхан, түрдэг тэрэг); **галт тэрэг** (уурын тэргээр төмөр замаар чирч хөдөлгөх олон вагон залгасан нэгэн бүхэл бүрэлдэхүүн; *хурдан галт тэрэг; шуудангийн галт тэрэг);* 2. автомобиль, авто-машин; **ачааны тэрэг** (ачаа ачих автомобиль); **суудлын тэрэг** (зөвхөн хүн суух хөнгөн маягийн автомобиль); **мухар тэрэг** *х у у ч и р с а н* (автомобиль); **нисдэг тэрэг** *х у у ч и р с а н* (нисэх онгоц); **тэрэгний боодой** (буулга); **тэрэгний гуя** (арал); **тэргэн одон** *з у р х а й* (долоон одон).

ТЭРЭГЛҮҮЛЭХ тэрэглэхийн үйлдүүлэх хэв.

ТЭРЭГЛЭХ тэрэг хэрэглэх, тэргэнд ачих, тэргэнд суух, тэргэн дээр тавих.

ТЭРЭГЧ 1. тэрэг үйлдэх хүн; 2. тэрэг хөтлөх хүн.

ТЭРЭМ I *у р г а м а л* хээр ургадаг нэг зүйл өвсөрхөг ургамал. үнэр анхилам сайхан.

ТЭРЭМ II гэрийн хана.

ТЭРЭЭХЭН тэрхэн.

ТЭС I эрс, шал, огт, бүр; *тэс буруу; тэс зөрүү;* **тэс өөр** (огт өндөө).

ТЭС II булга, мулт, бүлт; *нүд тэс цохих.*

ТЭС III дангинатал, сүрхий, бүр; *тэс хөлдөх; тэс хөлдүү.*

ТЭС IV *у р г а м а л* уулын тагаар ургадаг, гэргүүлэгч цэцгийн язгуурын нэгэн зүйл мод, жимсэнийг авч хэрэглэнэ.

ТЭСВЭР хатуужил, хүлцэл, хүлцэнгүй, тэвчээр; *зүдрэх цагт тэсвэр хэрэгтэй; тэсвэр муутай амьтан; тэсвэрээ алдах.*

ТЭСВЭРГҮЙ хүлцэл, хатуужил муутай, хүлцэл хатуужилгүй; *хатуужил тэсвэргүй.*

ТЭСВЭРЛҮҮЛЭХ тэсвэрлэхийн үйлдүүлэх хэв.

ТЭСВЭРЛЭХ хүлцэж чадах, даах, давах; *зовлон тэсвэрлэх; тэсвэрлэн давах; тэсвэрлэн өнгөрүүлэх.*

ТЭСВЭРЛЭШГҮЙ тэсч болшгүй; *тэсвэрлэшгүй халуун байв.*

ТЭСВЭРТЭЙ хүлцэл хатуужил сайтай; *хүйтэнд тэсвэртэй мал.*

ТЭСГИЙЛГЭХ тэсгэхийн үйлдүүлэх хэв.

ТЭСГИЙХ тэсгэгэр болох; *тэсгийсэн будүүн гэдэстэй; тэсгийсэн том юм; тэсгийтэл тргалах.*

ТЭСГЭГЭР бүдүүн, тарган, том, түсгэгэр, цүндгэр; *тэсгэгэр хүн; тэсгэгэр шар.*

ТЭСГЭЛ тэсвэр, тогтвор, биеэ барих чадвар.

ТЭСГЭЛГҮЙ 1. тэсвэргүй; *тэсгэлгүй хүн;* 2. тэсэшгүй; *тэсгэлгүй халуун; тэсгэлгүй сайхан; тэсгэлгүй хүлээх; тэсгэлгүй баярлах; тэсгэлгүй өвдөх.*

ТЭСГЭР тэсгэгэр.

ТЭСГЭХ I тэсэхэд хүрүүлэх, тэсүүлэх.

ТЭСГЭХ II татварлан авах, нийгэмчлэн авах; **тэсгэн татах, тэсгэн авах** (олноос нийгэн авах); **тэсгэн татварлах** (олноос нийгэн татварлах).

ТЭСИЙХ тэсгийх

ТЭСРҮҮЛЭХ тэсрэхийн үйлдүүлэх хэв.

ТЭСРЭГ эсрэг, сөрөг; **эсрэг тэсрэг** х о р ш.; **эсрэг тэсрэг явдал** (харилцан зөрчилтэй явдал); **тэсрэг салхи** (араас салхилах салхи).

ТЭСРЭМТГИЙ тэсэрдэг, хялбар тэсэрдэг; *тэсрэмтгий хий; тэсрэмтгий чанар.*

ТЭСРЭХ дэлбэрэх, дэлбэ үсрэх, хагарах; *тэсрэх бодис; агаарт тэсрэх; нүд тэсрэх.*

ТЭСТЭШГҮЙ тэсэшгүй.

ТЭСҮҮЛЭХ тэсэхийн үйлдүүлэх хэв.

ТЭСЭГ у р г а м а л говь хээрийн бүсэнд ургадаг олон наст бутлаг ургамал, өндөр нь 30—50 см. орчим, үслэг цайвар навчтай, өвөл хаврын цагт малд тэжээлтэй.

ТЭСЭМ тэсмээр.

ТЭСЭРГҮҮ эсэргүү; **эсэргүү тэсэргүү** х о р ш

ТЭСЭРГҮҮЛЭХ 1. итгэл найдвар, хишиг ачийг алдагдуулах, мартах; 2. тэсрүүлэх.

ТЭСЭХ хүлцэл, даах, давах; *хэдэн минут тэсч үз; их халуун байна, тэсэхгүй нь; тэсч ядах; тэсэхүйеэ бэрх;* **галд тэсэх тоосго** (халуунд тэсвэртэй тоосго).

ТЭТГИЙЛЭХ хүйтэнд даарч тий тий гэж өгүүлэх, дагжих.

ТЭТГҮҮЛЭХ 1. тэтгэхийн үйлдүүлэх хэв; 2. тэтгэгдэх.

ТЭТГЭВЭР тусламж, нэмэр; **тусламж тэтгэвэр** х о р ш.; *тэтгэвэр үзүүлэх; өндөр насны тэтгэвэр;* **өнчин ядуусын тэтгэвэр; тэтгэврийн газар** (эрэмдэг зэрэмдэг, хөдөлмөрийн чадваргүй бологсдыг тэжээж тэтгэх газар).

ТЭТГЭВЭРЛҮҮЛЭХ тэтгэвэрлэхийн үйлдүүлэх хэв.

ТЭТГЭВЭРЛЭХ тэтгэвэр өгөх, тусламж үзүүлэх.

ТЭТГЭГДЭХ тэтгэхийн үйлдэгдэх хэв.

ТЭТГЭЛТ I тэтгэлгэ, тэтгэмж, тэтгэвэр.

ТЭТГЭЛТ II бичигт он сар өдрийг тавих; *тэтгэлт нь зөв болсон биз?*

ТЭТГЭЛЭГ тэтгэх үйлийн нэр, тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлгэ; **тэтгэлгэ тусламж** х о р ш.; *тэтгэлэг үзүүлэх; тэтгэлэг өгөх.*

ТЭТГЭМЖ тэтгэсэн зүйл, тусламж, тэтгэвэр, тэтгэлт; *дүүгийнхээ тэтгэмжээр хөл дээрээ босов.*

ТЭТГЭМЖЛҮҮЛЭХ 1. тэтгэмжлэхийн үйлдүүлэх хэв; 2. тэтгэмжлэгдэх.

ТЭТГЭМЖЛЭГДЭХ тэтгэмжлэхийн үйлдэгдэх хэв.

ТЭТГЭМЖЛЭХ тэтгэмж үзүүлэх, тэтгэх; *ядарсан цагт нь тэтгэмжилж байв.*

ТЭТГЭХ I туслах, харгалзах, тусламж үзүүлэх, тэтгэмж үзүүлэх; *ядуу зүдүү хүмүүсийг тэтгэж байх.*

ТЭТГЭХ II бичгийн он сар өдрийг тавих; *энэ бичгийг 11-р сарын 23-наар тэтгээрэй.*

ТЭХ I янгир ямааны эр; *тэхийн эврийг тэнгэрт тултал; тэмээн сүүлийг газарт хүртэл хүлээх* з ү й р.

ТЭХ II я р и а чингэх, тэнгэх, тэгэх; *тэх нь ямар вэ? тэх нь зөв үү? би тэх санаатай байна, ямар вэ?*

ТЭХИЙ яг хагас, тэн хагас, яг дунд; *тэхий хагас нь;* **тэхий дундаа оров** (яг нэгэн хагасдаа оров).

ТЭХРҮҮЛЭХ тэхрэхийн үйлдүүлэх хэв.

ТЭХРЭХ хойш буцах.

ТЭХҮҮН увайгүй, дээрэнгүй; *тэхүүн зантай.*

ТЭХЭЛ харил, буцал.

ТЭШГҮЙ сүрхий, овоо; *тэшгүй сайн ат; тэшгүй зантай хүүхэд вэ, чи?*

ТЭШИХ 1. хазгай газар халтиран унах; *хазгай газар тэшиж явчихуузай!;* 2. тэшүүрээр гулгах; *гулгуур дээгүүр тэшиж наадах;* 3. тэмээний давхих; *тэмээ тэших;* 4. харвасан сум газарт хавирах; *сум тэшиж очоод оножээ.*

ТЭШҮҮ ташуу.

ТЭШҮҮЛЭХ тэшихийн үйлдүүлэх хэв.

ТЭШҮҮР 1. гулгуур; *тэшүүрийн талбай;* 2. гуталд бэхлэж, мөсөн дээгүүр гулгах зэвсэг; *уралдааны тэшүүр; тэшүүрээр гулгах.*

ТЭШҮҮРЧ тэшүүрээр гулгагч; *соёл нийгэмлэгийн тэшүүрчид.*

ТЭЧЬЯДАЛТАЙ тэсч ядалтай; *дан ч тэчьядалтай.*

ТЭЧЬЯДАМ тэсч ядам, тэсэхүйеэ бэрх.

ТЭЧЬЯДАХ тэсч ядах, хэтэрхий бачимдах, амь тэмцэх, тэсэшгүй болох; *чингэхэд нь тэчьядах юм; тэчьядан хорсох; бачимдаж тэчьядах хэрэггүй.*

ТЭЭВЭР тээх ачаа барааны зүйл; **ачаа тээвэр, жин тээвэр, зам тээвэр** х о р ш.; *тээврийн товчоо; тээвэр хийх; агаарын тээвэр; төмөр замын тээвэр;* **тээврийн тэрэг** (ачаа бараа зөөх тээхэд зориулсан тэрэг); **хулгайн тээвэр** (хүн юмыг нуун тээвэрлэж хөлс ашгийг хувьдаа жавших).

ТЭЭВЭРЛҮҮЛЭХ 1. тээвэрлэхийн үйлдүүлэх хэв; 2. тээвэрлэгдэх.

ТЭЭВЭРЛЭГДЭХ тээвэрлэхийн үйлдэгдэх хэв.

ТЭЭВЭРЛЭХ тээвэр тээх; *ачаа бараа тээвэрлэх; хүн тээвэрлэх.*

ТЭЭВЭРЧИН тээврийн ажил хийгч; *ноос тээвэрчин.*

ТЭЭГ I 1. юмыг тээглэн тогтоох хэрэгсэл; *хэтний тээг; аяганы арчуурын чулуун тээг;* 2. түгжээ; *үүдний тээг.*

ТЭЭГ II: **тээг тээг** дэвхрэн дэвхрэн, онтос онтос; *тээг тээг явдалтай, тэвхэн сайран гуталтай, алаг булаг дахтай, алтан уурга чирээстэй* (оньсго).

ТЭЭГЛҮҮЛЭХ 1. тээглэхийн үйлдүүлэх хэв; 2. тээглэгдэх.

ТЭЭГЛЭГДЭХ тээглэхийн үйлдэгдэх хэв.

ТЭЭГЛЭХ 1. тээгээр торгох, тогтоох; *тээгээр тээглэх;* 2. торгох, саад болох; *хөлд нэг юм тээглэв; галгисан юм хоолой дээр тээглэх нь эвгүй; хэлэх гэсэн үг цээж дээр тээглэж орхив.*

ТЭЭГЧ тээдэг хэрэгсэл; **нисэх онгоц тээгч** (нисэх онгоцны хөлөг).

ТЭЭГЭЛДЭХ тээглэхийн үйлдэгдэх хэв, тээглэж торох; *босгонд тээгэлдэн унах; хоолой дээр юм тээгэлдэх.*

ТЭЭДҮҮЛЭХ 1. тээдэхийн үйлдүүлэх хэв; 2. ш и л ж с э н баширлан гэнэдүүлэх, мэхлэх, маллах.

ТЭЭДЭХ хэлэлцэхэд зөрсголзох, түгдрэх.

ТЭЭЛ хайч зэрэг юмны хадаас; *хайчны тээл.*

ТЭЭЛГЭХ тээхийн үйлдүүлэх хэв.

ТЭЭНЭГЛЭХ санаа сэтгэл хоёрдож саармаглах.

ТЭЭНЭГЭЛЗЭХ шийдвэрлэж ядах, санаа хоёрдох; *шийдвэрлэж чадахгүй тээнэгэлзэх.*

ТЭЭР дараас; **тээр дараас** х о р ш.: *тээр болох; тээр үзэх; тээрийн нэмэр.*

ТЭЭРТЭЙ дараастай, саадтай; *энэ чинь харин тээртэй хэрэг байна даа.*

ТЭЭРҮҮЛЭХ тээрэхийн үйлдүүлэх хэв.

ТЭЭРШЭЭХ тээр дараас болгож үзэх, бэрхшээх.

ТЭЭРЭМ будаа тариаг гурил болгож тээрэмдэх зэвсэг; **уеан тээрэм** (усаар хөдлөх тээрэм); **салхин тээрэм** (салхины хүчээр хөдлөх тээрэм); **гар тээрэм** (гараар эргүүлж будааг гурил болгох зэвсэг); **цахилгаан тээрэм** (цахилгааны хүчээр хөдлөх тээрэм); **тээрэмд орох** (тээрмээр гурил татах); **тээрмийн морь** (тээрэмд зүтгүүлэх морь); **тээрмийн хүйс** (тээрмийн чулууны голын нүх); **тээрмийн чулуу** (будаа няцлах чулуу).

ТЭЭРЭМДҮҮЛЭХ тээрэмдэхийн үйлдүүлэх хэв.

ТЭЭРЭМДЭХ тариа будааг талхалж гурил болгох; *гурил тээрэмдэх.*

ТЭЭРЭМЧ тээрэм ажиллуулагч.

ТЭЭРЭХ I их л цадаж хэвэл хүнддэх, хэвэл дүүрч аягүй болох.

ТЭЭРЭХ II бөгчим халуунд малын хорон зогсох, хорох; *энэ өдрийн халуунд мал тээрээд сүрхий байна шүү.*

ТЭЭХ 1. ачаа бараа зөөх; *тээх нэвтрүүлэх хороо; тээвэр тээх; тэмээн тэргээр тээх;* 2. үүрч, өргөж удтал явах; **гэдсэн дотроо тээх** (жирэмсэн явах); 3. бөгцэг няслахад шагааг нэгэн хуруунд наалдуулан өөр шагааны дээгүүр өргөж аваачих; *шагаа тээх.*

ТЭЭХЭЛЗЭХ өргөн цээж гарган ханхалзах, хаахалзах, таахалзах; *биеэ гайхуулж тээхэлзэх.*

ТЭЭШ 1. ачаа; **ачаа тээш** х о р ш.; галт тэрэг, галт онгоц, нисэх онгоцоор явуулах баглаж бэлтгэсэн ачаа, зорчигчийн ачаа; *тээш хадгалах газар; алс явахад илүү тээш авч явахын хэрэг байхгүй;* **гарын тээш** (зорчигчийн *биедээ авч явах юм*).

У

У I У авиа, У үсэг.

У II бөхийн угтуулыг товчлон хэлэх үг; **у юу, а юу** (угтуул уу, ам уу).

УВ хүч нэмэгдүүлэх үг, час; *ув улаан хацартай.*

УВАА: уваа цуваа х о р ш.; нэг хоёроор цувж, уван цуван.

УВААН: уваан буурцаг у р г а м а л урт гонзгой хүүдийд буурцаг нь байдаг таримал ногоо, үр болоод буурцгийг идэж болно.

УВАЙГҮЙ 1. биеэ үгүйлэхгүй, давамгай зан байдалтай; *увайгүй зантай; битгий увайгүй зан гарга;* 2. царай алдсан, доожоогүй, хуншгүй; *увайгүй харамч амьтан.*

УВАЙЛАХ тоомсорлох, хайхрах; *хүйтэнд увайлахгүй байв;* **увайлсангүй** (тоомсорлосонгүй).

УВАН: уван цуван нэгэн зэрэг биш, цувран; *уван цуван ирэх; уван цуван явах.*

УВДИС нууц эрдэм, чадал; *увдис үзүүлэх.*

УВДИСЛАХ увдис шингээх, увдистай болгох.

УВДИСЛУУЛАХ увдислахын үйлдүүлэх хэв.

УВСАНЦ чавганц.

УВШ гэнэн сахилтан.

УГ 1. ёзоор, язгуур; *модны уг; хэлний уг; миний үсний угаас цайж байна;* 2. ш и л ж с э н үүсгэл, анх, эх; *уг чанар нь; уг нутаг; уг шалтгаан; уг заасан газар; уг хэрэг; уг үндэс; би угаасаа говийн хүн; үгийн ажилсаг хүн;* **зүрхний угаас** (үнэн сэтгэлээс); **уг нь** (уулаас, ерөөс); **уг туйл** (угийн мохоол); ☆ **угийн бичиг** (гэрийн үеийн бичиг).

УГААГДАХ 1. угаахын үйлдэгдэх хэв; 2. угаасан мэт гилгэр, юу ч үгүй болох; *үерт угаагдах.*

УГААГУУР угаадаг зэвсэг; *тогооны угаагуур; лонхны угаагуур; угаагуурын түмпэн; угаагуурын гүц; угаагуур машин.*

УГААДАС юм угаасан бохир ус; *угаадасны нүх; угаадас асгах.* • •

УГААДАСЛАХ угаах. • •

УГААЛ угаах үйлийн нэр; *угаал хийх; угаал үйлдэх;* **угаалын гадар** (юм угаах сав); **угаалын тэвш** (бие угаах сав); **наран угаал** (нарны гэрэлд ээж бие чийрэгжүүлэх эмнэлэг).

УГААЛГА угаах үйлийн нэр; *угаалгын газар; хуучин хувцсаа угаалганд өгөх;* **хүүхдийн угаалга** (төрсөн хүүхдийг угаах ёслол).

УГААЛГАХ угаахын үйлдүүлэх хэв, угаахад хүргүүлэх.

УГААЛТ угаасан байдал; *энэ цамцны угаалт муухан болжээ.*

УГААЛТУУР угаадаг, арчдаг, цэвэрлэдэг юм; *тогооны угаалтуур.*

УГААЛЦАХ угаахын үйлдэлцэх хэв.

УГААЛЦУУЛАХ угаалцахын үйлдүүлэх хэв.

УГААЛЧ (ИН) угаалга хийдэг хүн; *эмнэлгийн газрын угаалчин; хувцас угаалч.*

УГААХ I. нойтон юмаар цэвэрлэх; *усаар угаах; гар нүүр угаах; тогоо угаах; биеэ угаах;* **ноос угаах газар** (ноос цэвэрлэх газар); **юм угаах машин** (хувцас зэрэг юмыг өөрөө угааж цэвэрлэх машин); **хүүхэд угаах** (хүүхдийн угаалга хийх); 2. ш и л ж с э н угаасан мэт гилгэр болгож орхих; 3. ш и л ж с э н сур, шагааг дөрвөн сумаанд үл онох; *би шагаа харвахдаа дөрвөн сумаа угаачихдаг байгаа.*

УГААШ дотуур хувцас зэрэг даруй даруй угааж сольдог гэр зуурын даавуун хэрэглэл; *угаашийг солих.*

УГАЛЗ I а м ь т а н бие чийрэг, эвэр том, зэрлэг хонины эр нь; *аргаль угалз манай оронд элбэг бий; зааны ширээр хөхүүр хийж, угалзын эврээр утгуур хийж...* (ерөөл).

УГАЛЗ II гоёмсог чимэг болгон хэрэглэх, эргэлдсэн дугуй хэлбэртэй хээ; **хээ угалз** х о р ш.; *угалзтай гутал; угалз оёх; угалз наах; угалз хатгах;* **угалз тавих** (угалз гаргаж зурах, будах, оёх).

УГАЛЗ III говь цөл газар болдог хүчтэй элсэн хуй салхи; угалзан хуй.

УГАЛЗАРХАГ угалз ихтэй.

УГАЛЗАРХУУ 1. угалзархаг; 2. угалз мэт.

УГАЛЗЛАХ 1. угалз гаргах, угалз тавих; 2. угалз шиг болох; *угалзлан урсах гол.*

УГАЛЗЛУУЛАХ угалзлахын үйлдүүлэх хэв.

УГАЛЗТАЙ угалз бүхий; *шагаа зулаг дээрээ угалзтай гутал.*

УГЖ нялх хүүхэд, нялх амьтны сүү хөхөх хөндий гуурс буюу эвэр зэрэг зүйл; *угжаар тэжээх;* **угжны хөхөл** (угжны шимүүл); **угжны хүүхэд** (угжаар тэжээдэг хүүхэд).

УГЖИХ угж хөхүүлэх, шимүүлэх; *нялх хүргыг сүүгээр угжих болгов.*

УГЖУУЛАХ угжихын үйлдүүлэх хэв.

УГЗ урагш үгтээн татах гэсэн утгатай хүч нэмэгдүүлэх үг; *угз татах; унасан бор морь нь ам булаалдан жолоогоо угз угз татаж явав.*

УГЗРАЛТ угзрах үйлийн нэр; *угзралтын хүч.*

УГЗРАХ угз татах, хүчтэй огзом татах, үгтээн татах; *нэгэн удаа угзраад дийлсэнгүй; морины амыг угзрах.*

УГЗРУУЛАХ угзрахын үйлдүүлэх хэв.

УГЗЧИХ байн байн угзрах; *дээл дээрээс нь байн байн угзчиж байв.*

УГЗЧУУЛАХ угзчихын үйлдүүлэх хэв.

УГЛАА угладаг, углаж өмсгөх юм; **гэрийн углаа бүрээс** (гэрийн дээрээс өмсгөх битүү бүрээс); **углаа цамц** (толгойгоор өмсөх цамц).

УГЛАРГА углуурга.

УГЛАХ 1. дүрэх, оруулах; *хаалганы үглуурыг углах;* 2. өмсөх; *хуруундаа углах;* **цамцаа толгойдоо углах** (дутуу зэмдэг өмсөх).

УГЛУУЛАХ углахын үйлдүүлэх хэв.

УГЛУУР углуургын сувэнд үмхүүлэх хэсэг нь; *хаалганы үглуур.*

УГЛУУРГА углуурт өмсгөх нүх, угларга; *гансны үглуурга; хаалганы үглуурга.*

УГЛУУРГАДАХ углуурга гаргах, углуурт шургуулах; *гансны мод үглуургадах.*

УГСАА I 1. үндэс, сурвалж; **үндэс угсаа, яс угсаа** х о р ш.; *муу угсаа;* **сайн угсааны мал** (цэвэр цусны, сайн үүлдрийн мал); 2. х у у ч и р с а н хаад ноёдын төрөл, язгуур, удам; **удам угсаа** х о р ш.; **угсаа залгамжлах** (хаад, ноёдын хөвгүүд төрлийн хүмүүсээс тэдний хэргэм зэрэг тушаалыг залгамжлан авах).

УГСАА II цулбуур **жолооны** гогцоо шижим.

УГСААЛАГ сайн угсааны шинж тэмдэг илэрхий тэжээвэр амьтан болон ургамал.

УГСААЛАХ I угсаа гаргах.

УГСААЛАХ II угсаа удам залгамжлах.

УГСААТАЙ угсаа бүхий.

УГСААТАН 1. үндэстэн; **угсаатны зүй** (үндэстний эдийн ба оюуны соёлыг судлах ухаан); 2. х у у ч и р с а н хаад ноёдын язгууртан.

УГСААР төрлөөр.

УГСАРМАЛ угсарсан юм. *угсармал байшин.*

УГСРАА угсрах үйлийн нэр: цувраа, дараагаар; залгаа; *угсраа гурван гэрийн дундах нь; угсраа хэдэн толгод; угсраатай тэрэг; хоёр кино угсраагаар гарав;* **угсраа байшингийн үйлдвэр** (байшинг угсарч барихад зориулан хана, тааз зэрэг хэрэгслийг үргэлж үргэлжээр үйлдвэрлэх үйлдвэр).

УГСРАГЧ угсрах үйл гүйцэтгэгч.

УГСРАХ 1. эвлүүлж бүтээх, босгох, байгуулах; *байшин угсрах; машин угсрах; эмээл угсрах;* 2. дараагаар дахих; *гурав угсарч дуулах; хэд угсран цай чанах.*

УГСРУУЛАХ угсрахын үйлдүүлэх хэв.

УГСУУРГА 1. эмээлийн олом жирэм уях суран гогцоо; 2. эмээлийн хойт хавтсанд худрагыг торгож тогтоохын тул хадсан тусгай жижигхэн булигаар, сур зэрэг юм.

УГТАХ 1. тосох, өмнөөс очих; *зочдыг угтах, хаалган дээрээ угтан гарч ирэв; дайсныг угтан байлдах;* 2. аливаа ирээдүй юм, үйл явдлыг тосох; *сонгуулийг угтсан хөдөлмөрийн амжилт; Улсын баярыг угтсан уралдаан;* 3. урьтах, түрүүлэх; **угтан хэлэх** (урьтаж хэлэх).

УГТВАР үгийн үндэс, язгуурын өмнө ордог утга бүхий хэсэг; *үгийн угтвар дагавар.*

УГТЛАГА 1. угтах нь; **угтлагын хурал** баяр ёслолыг тэмдэглэх өдрийн өмнө хийх хурал); 2. угтуул

УГТУУЛ 1. угтах хүн; *зочдын өмнөөс угтуул явуулав;* 2. амлан авах буюу ахлах цолтой бөх, ахлах талаас боссон бөх; 3. бийрийн дуг-туй, ☆ **угтуул цэцэг** у р г а м а л (цэцэг нь дүгрэгхэн бөгөөд урт, хэлтэс харавтар улаан, хувцсанд хүрвэл үнэр авд арилахгүй нэг зүйл цэцэг).

УГТУУЛАХ угтахын үйлдүүлэх хэв.

УГЦ огцом, гэнэт, сочмог; *угц гэмтэх; угц тасрах.*

УГЦРАХ I алдуурах, сулрах.

УГЦРАХ II огцрох.

УГШГҮЙ урагшгүй, болхи, дорой, хөдөх; *угшгүй амьтан даа.*

УД у р г а м а л дурс зузаан, гол зөөлөн, навч уртхан, салаа мөчир төлөв шулуун урт мод, төрөл зүйл олон; **уд тайх** х у у ч и р с а н (бөө нар уд мод босгож цалам дээс татан уяж буян гуйн тайх зан үйл).

УДАА 1. зэрэг дугаарын дэв; **удаа дараа** х о р ш.; *анх удаа уулзав; удаа дараа бичсэн захидлын тоо;* 2. таа, дахин; *хэдэн удаа асуув; хоёр дахь удаагаа ирж байна;* 3. дараа, сүүлд; *чиний удаа би ирэв.*

УДААДАХ хэтэрхий удаан болох; *явдал чинь арай л удаадаад байна.*

УДААДУУЛАХ удаадахын үйлдүүлэх хэв.

УДААН 1. цаг үлэмж нөхцөөх, их цаг хэрэглэх нь; *бид тэнд удаан суув; удаан цаг явах; удаандаа даамгай; түргэндээ түүхий* з ү й р; 2. алгуур, хөдлөх нь хурдан биш, **удаан хөлтэй** (хурдан үл явах); ☆ **удаан самж** а м ь т а н (самжнаас их ус харавтар, юманд сониучхан нэг зүйл самж).

УДААРАХ 1. дараалах, дэслэх, удаа дараагаар болох; 2. удаашрах, удаан болох.

УДААРУУЛАХ удаарахын үйлдүүлэх хэв.

УДААСАХ улам удаан болох.

УДААСГАХ удаасахын үйлдүүлэх хэв, удаасахад хүргүүлэх.

УДААТАХ улмаар удаан болох.

УДААТГАХ удаатахын үйлдүүлэх хэв, удаадахад хүргүүлэх.

УДААХ I удахын үйлдүүлэх хэв, удахад хүргүүлэх; *харцуу өгөхгүй удаах.*

УДААХ II өдөх, сэдэх; *хэргүүл удаах үг; удаах; түвэг удаах.*

УДААХАН нилээд удаан, баахан удаан.

УДААХЬ дараахь, хойтохь; *удаахь хүн нь би.*

УДААШРАХ удах, удаан болох, *харцуу ирэхгүй удаашрав; дэндүү удааширч байна.*

УДААШРУУЛАХ удаашрахын үйлдүүлэх хэв.

УДАЛ удах үйлийн нэр; *удалгүй ирнэ; би ажил дээрээ удалтай бол хүнээр хэлүүлье.*

УДАМ 1. угсаа, төрөл; **угсаа удам, удам сударх о р ш.**; *сайн удам; муу удам; хурдны удамтай морь;* 2. угсаагаар дамжих бэлэг тэмдэг; *манайхан урт насалдаг удамтай;* **удам судрыг дуудах** (хүний өвөг дээдэс угсааг сөхөж өгүүлэх).

УДАМБАР у р г а м а л иш арван тохой, өндөр, навч нь зөөлөн, бас бүдүүлэг ширүүн ч бий, цэцгийн дэлбээ нь гарын алга мэт том, олон цэцгийн дунд буюу эсвэл уулын далд газар ургадаг ургамал,

УДАМЛАХ удмаа дууриах.

УДАМЛУУЛАХ удамлахын үйлдүүлэх хэв.

УДАМТАЙ 1. удам бүхий; 2. удам сайтай; *удамтай гүүний унага.*

УДАМШИЛ удам угсаа, садан төрлөөс аливаа амьд махбодид дамжиж ирсэн чанар шинж төлөвийн цогц.

УДАМШИХ удамшил тогтох, удамшилтай болох.

УДАМШУУЛАХ удамшихын үйлдүүлэх хэв.

УДАР: удар татах хагз татах.

УДАРНИК социалист үйлдвэрлэлийн тэргүүний ажилчин.

УДАСХИЙХ баахан удах.

УДАХ I 1. цаг улирч нөхцөх; *юу удах билээ дээ; удаж байгаад уулзсан янаг, ундаасч байгаад уусан ус* з үй р; 2. удаан байх; *би удна шүү; хотод ирээд удаж байна.*

УДАХ II дэгдээх, үүсгэх; *яршиг удах; хэргүл удах; ам хэл удах.*

УДВАЛ 1. у р г а м а л иш ногоон, навч зургаан уулзартай, цэцгийн хэлтэс ес, эрт цэцэглэж үдэш хамхина, өнгө нь улаан, үнэр анхилам сайхан цэцэг; 2. у р г а м а л иш өндөр богино адилгүй, навч уулзартай, өнгө янз бүр, есдүгээр сард цэцэглэнэ, үнэр сайхан цэцэг.

УДГАЛАХ 1. удганы бөөлөх; 2. морины нэг зүйл явдал.

УДГАЛУУЛАХ удгалахын үйлдүүлэх хэв.

УДГАН эм бөө: **бөө удган** х о р ш.; **удган хатир** (морины нэгэн зүйл явдал); **удган эрвээхий** а м ь т а н (шөнө гарч нисдэг эрвээхийнүүдийн ерөнхий нэр); **удган ээрүүл** (хүүхэд эргүүлэн наадах тоглоом).

УДИРДААЧ найрал дуу хөгжмийг удирдах хүн; *үлээвэр хөгжмийн удирдаач.*

УДИРДАГЧ тэргүүлэгч, толгойлогч, жолоодогч, зааварлагч; *ард түмний удирдагч; уран сайхны удирдагч; эрдэм шинжилгээний удирдагч.*

УДИРДАЛТ удирдах үйлийн нэр, удирдах үйлийн явц; *хурлын удирдалт.*

УДИРДАМЖ удирдлага болговол зохих зүйл; *Төв хорооны удирдамж; дээрээс ямар удирдамж өгсөн бэ?*

УДИРДАХ 1. хойноосоо дагуулах; *газарч удирдан явав;* 2. тэргүүлэх, толгойлох, жолоодох; *удирдах тушаал; ажилчны хөдөлгөөнийг удирдах.*

УДИРДЛАГА удирдах үйлийн нэр; *намын удирдлага; даргын удирдлагын дор явав.*

УДИРТГАЛ 1. удирдах нь; **удиртгалын далбаа** (усан онгоцны далбаа); 2. ном зохиолын эхний, тэргүүний анги, хэсэг; *зохиолын удиртгал; удиртгал үг.*

УДРАХ 1. задрах, ханзрах; *дээл удрах; гэрийн бүрээс удрах;* 2. ш и л ж с э н гаарах, ихдэх; *хэрэг удрах; өвчин удрах.*

УДРУУЛАХ удрахын үйлдүүлэх хэв.

УДЧИХ байн байн удрах, задчих.

УДЧУУЛАХ удчихын үйлдүүлэх хэв, удруулах, задчуулах

УЖИГ удаан, нөр, назгай; **ужиг өвчин** (түргэн эдгэрэхгүй өвчин); **ужиг хүн** (удаан назгай хүн).

УЖИГЛАХ ужиг болох, удах.

УЖИД I 1. өж, нөр, махруу; 2. зөрүүд, зүтгээ.

УЖИД II садар самуун.

УЖИДЛАХ I 1. өжих, нөрөх, махрах; 2. зөрөх, зүтгэх.

УЖИДЛАХ II садар самуун аашлах, самуурах.

УЖИДЛУУЛАХ ужидлахын үйлдүүлэх хэв

УЖИХ удаашрах, удах, ужиг болох.

УЗУУР ёзоор, бөгс.

УЙ үхэгсдийн хойноос гашуудах эмгэнэл; **уй гашуу** х о р ш.; **уй хийх** (уйн ёслол хийх); **уй тайлах** (уй хийхийг болих).

УЙГАГҮЙ амралтгүй, цөхрөлтгүй, залхуугүй; *уйгагүй ажиллах; уйгагүй оролдох.*

УЙГАРЛАХ уянгатай удаан дуугарах.

УЙГУР Турк аймгийн нүүдэлчин улсын нэр; *Уйгур үсэг; Уйгурын соёл.*

УЙДААХ уйдахын үйлдүүлэх хэв, уйдахад хүргүүлэх.

УЙДАМ уйдмаар.

УЙДАХ I 1. уйтгарлах, хийх юмгүйд сэтгэл амаргүй болох; *ганцаараа уйдах;* 2. дургүй болох, таалалгүй болох; *надаас уйджээ.*

УЙДАХ II углуур мэтийн холхидог, сул болох; *уйтан болох; уйдсан эрэг.*

УЙЛ 1. усны хоролзон эргэлдэх газар, усны эргүүлэг; 2. үсний эргүүлэг, модны эргүүлэг; *үсний уйл.*

УЙЛАА уйламтгай.

УЙЛААН уйлалдаан; **уйлаан майлаан** х о р ш.; *уйлаан болох; уйлаан майлаан болж байна.*

УЙЛАГНАХ уйлах янз байдал гаргах; *уйлагнан уйлах; уйлагнан дуугарах.*

УЙЛАЛДААН уйлалдах үйлийн нэр, олноороо уйлах.

УЙЛАЛДАХ уйлахын үйлдэлдэх хэв.

УЙЛАМТГАЙ уйлахдаа хялбар, уйламхай; *уйламтгай хүүхэд.*

УЙЛАМХАЙ уйлах зантай, амархан уйлдаг, их уйлдаг, уйлахдаа хялбар, уйламтгай, уйланхай.

УЙЛАНХАЙ I амьтны бие махбодийн дотор өвчнөөр бий болох цулцан, хавтгай цагаан хорхойн торних нэг үе болох битэг буюу битэгний гэр.

УЙЛАНХАЙ II уйламтгай, уйламхай.

УЙЛАНХАЙТАХ I уйлагнаж ярих.

УЙЛАНХАЙТАХ II уйланхай бий болох; 2. уйланхай мэт цөврүүтэх.

УЙЛАНХАЙТУУЛАХ уйланхайтахын үйлдүүлэх хэв.

УЙЛАХ өвдөх, гомдох зэрэгт нүднээс нулимс асгаруулах; **уйлах майлах, уйлах унжих, уйлах хайлах** х о р ш.; *гашуудан уйлах; уйлж унжих; уйлсан хүний учир бүү асуу, инээсэн хүний учир асуу* х у у ч.

УЙЛУУЛАХ уйлахын үйлдүүлэх хэв.

УЙЛХАЙ уйламтгай, уйламхай.

УЙМАХ I ус сүлжин гатлах; *усанд уймах.*

УЙМАХ II элбэг хүрэлцэх, элбэг дэлбэг байх.

УЙМРАА сэтгэл тогтворгүй, сандруу; *уймраа хүн; уймраа зан.*

УЙМРАХ уймраа зан гаргах, санаа тогтворгүй байх, сандрах; *санаа сэтгэл уймрах.*

УЙМРУУЛАХ уймрахын үйлдүүлэх хэв.

УЙСАХ уйдах.

УЙТАВТАР баахан уйтан, арай уйтан.

УЙТАЙ уй бүхий; *уйтай цаг.*

УЙТАН хувцасны явцуу; *уйтан ханцуйтай дээл; уйтан гутал;* **уйтан эгшиг** (хэлэхэд амны хөндийн байдал явцуу болдог эгшиг).

УЙТАТГАХ улам уйтан болгох.

УЙТАТГУУЛАХ уйтатгахын үйлдүүлэх хэв.

УЙТГАР 1. сэтгэл тогтохгүй шаналах зовлон; *уйтгартай өдөр; уйтгар хүрэх;* **уйтгараа сэргээх** (уйдахын зовлонг мартуулах); 2. гуниг, эмгэнэл; *уйтгартай хөөжим.*

УЙТГАРЛАХ 1. уйтгар хүрэх, уйдах; 2. сэтгэл шаналан зовох, гунигтай болох; *уйтгарлан зовох.*

УЙТГАРЛУУЛАХ уйтгарлахын үйлдүүлэх хэв.

УЙТГАРТАЙ уйтгар бүхий; *уйтгартай царай; уйтгартай дуу.*

УЙТГАХ уйтан болгох.

УЙТГУУЛАХ уйтгахын үйлдүүлэх хэв, уйтан болгуулах.

УЙТДАХ хэтэрхий уйтан болох.

УЙТДУУЛАХ уйтдахын үйлдүүлэх хэв.

УЙТТАХ улмаар уйтан болох.

УЛ 1. хөл, гутал, оймсны гишгэх доод тал, таваг; *хөлийн ул; улны шир; улыг хатгадаг зангуу, ургах үедээ зөөлөн, улсыг сүйтгэдэг залихайн урууллын үзүүр зөөлөн* з үй р; 2. зарим багаж хэрэгсэл зүйлийн доод тал, элгэн тал; *оёдлын машинын ул төмөр; харуулын ул; чарганы ул;* 3. ш и л ж с э н суурь, иш, баримт; **улы нь олох** (магадлах, лавы нь олох); **ултай хөдлөх** (суурьтай хөдлөх); **ул авах** (иш авах); **ул шагаах** (бусдын гэм буруутай зүйлийг далдуур харж хайх; *бусдын улыг шагаасан булай муухай амьтан шүү).*

УЛАА х у у ч и р с а н албан хэргээр явахад ардын мал хөрөнгөнөөс унах эдлэх эрхийг олсон хүний хэрэглэх уналга, ачлага; **өртөө улаа** (өртөөнөөс хэрэгсэх улаа); **уургын улаа** (аль тохиолдсон адуунаас морь хөсөг барьж хэрэглэх улаа); **улаа барих** (уналга хөсгийг албадан хэрэглэх); **улаа нэхэх** (уналгаа авахаар дагах); **улаа шүүс** (элчийн хоол унд); **улааны морь** (улаа залгуулж байх морь); **улааны зар** (улаа хэрэгсэх үнэмлэх бичиг).

УЛААВАР улаанд шар буюу хар хольцсон өнгө.

УЛААВТАР нилээд улаан, улаан голлосон нь; *улаавтар туяатай.*

УЛААГАНА у р г а м а л бөөрөнхий улаан жимсгэнэтэй сөөг ургамал, жимсгэнийг идэж болно, амт амтайхан, бас чанамал хийнэ.

УЛААГЧ (ИН) эм малын улаан зүсэм; *улаагч үнээ; улаагчин тахиа жил.*

УЛААДАХ I улаа хэрэглэх; *улаадаж явах.*

УЛААДАХ II хэтэрхий улаан болох, улаандах.

УЛААДУУЛАХ улаадахын үйлдүүлэх хэв.

УЛААЛАХ 1. улаа хэрэглэх, улаа хэрэгсэн явах; 2. ш и л ж с э н бусдын хөрөнгийг дураар хэрэглэн явах.

УЛААЛЗГАНА у р г а м а л шүүйд хонгорцоглон ургана, янз үзмийн адил, өнгө улаан, амт хүчтэй, хүжний үнэртэй жимсгэнэ.

УЛААЛУУЛАХ улаалахын үйлдүүлэх хэв.

УЛААН 1. цусны өнгө мэт өнгө; *улаан туг; улаан будаг; улаан дарс; улааныг үзэж урвах, шарыг үзэж шарвах* з үй р; **ертөнцийн гурван улаан** (жавартай тэнгэрийн хаяа улаан, жартгай хүний нүд улаан, жалганд ургасан сухай улаан); **улаан бор** (малын зүсэм, борд улаавтархан өнгө хольцолдсон; *улаан бор морь);* **улаан шарга** (шарга зүсмийн адууны бяцхан улбар); **улаан цоохор** (а. үхэр, хонь, ямааны зүсэм цагаанд улаан толботой буюу улаанд цагаан толботой; б. бусад юмын улаан өнгөнд өөр өнгө буюу өөр өнгөнд улаан толбо бүхийг); **улаан тарлан** (үхрийн зүс улаан эрээн); **улаан зээрд** (улаан зүсмийн адууны баахан улбар); **улаан хүрэн** (тэмээ, үхэр, хонь, ямааны зүс ба эд юмны өнгө улбар хүрэн); **улаан хонгор** (хонгор зүсмийн адууны бяцхан улбар); **улаан халтар** (нохойн зүсэм; их бие хар бөгөөд завьж, шанаа, нүдний дээд этгээд, дөрвөн хөлийн шилбэ улаавтар); **улаан хээр** (хээр зүсмийн адууны баахан улбар); **улаан зүр** (зуны цагт зүр гөрөөсний өнгө улаавтархан харагдах өнгөөр нь ийн нэрлэнэ); **улаан нэлий** (а. цус ихэд асгасан, нялзсаныг; б. мах, цус ихэд тархсан зэрэг); **улаан бэх** (шунхыг талхалж, усанд хайлж цавуу холиод бэхийн адил дөрвөлжлөн хийснийг); **улаан мөнгө** (зэс гууль зэргээр үйлдсэн зоос; *улаан мөнгөний үнэгүй эд байна);* **улаан арьстан** (Европынхон Америк тивд нүүдэллэн очихын өмнө тэнд оршин сууж байсан хүн ардын нэр); **улаан цах** (сая төрсөн хүүхэд); 2. ш и л ж с э н хувьсгалын утга чанар бүхий; *Зөвлөлтийн хүчирхэг улаан арми; Улаан цэрэг; улаан булан; улаан гэр;* 3. ш и л ж с э н биеэр, халхлах юмгүй; **улаан тулгарах** (яг тулгарах); **улаан нүцгэн** (а. маш ядуу учир хувцас хунар муутай хүн; б. биедээ өмссөн хувцасгүй нүцгэлсэн; в. ус, мод, өвсгүй буюу маш тачир газар); **улаан гараараа уулзах** (ажил үйлдвэрийг зөвхөн гар биеэр хийх); **улаан нүүрээрээ учрах** (өөрийн биеэрээ учрах); **улаан зээрд болох** (баахан согтох); 4. ш и л ж с э н шунахай, ховдог, баллмад; *мөнгө цагаан, нүд улаан* з үй р; **улаан цайн гүжирдэх** (огт оргүй гүжирдэх); **улаан дайрах** (а. айх эмээх ба ичих зовохыг мэдэхгүй дайрах; б. нохой давхих болон бөхчүүд

барилдах зэрэгт далтирахгүй шууд тулж орох); **улаан буудай** ургамал (янз буудайтай адил болоод өнгө баахан улаавтархан нэг зүйл тариа); **улаан хоног** ургамал (хоног амуутай адил боловч хивэг улаан тариа); **улаан бударгана** ургамал (говь газар ургадаг бударганы нэг зүйл, өндөр нь метр хүртэл бий, иш мөчир найлзуур цайвар шар, зуны цагт жижиг ногоон навчтай, өвөл хатахдаа улаан болно, тэмээ иднэ, хатаж навчийг унасан цагт найлзуурыг адуу, үхэр бага зэрэг иднэ); **улаан харгана** ургамал (гүн говиос бусад газар их төлөв бий, язгуурт хожуултай, хальс бор шар, нарийн салаа мөчрийн үзүүр бүрд хурц өргөстэй, навч ногоон, цэцэг шар, хонь ямаа, тэмээ цөм иддэг нэг зүйл харгана); **улаан түлэй** ургамал (голдуу цөл, заримдаг цөлийн бүсэнд 10—50 см өндөр ургадаг, бут мөчир нь гялгар цайвар хальстай, үр зууван, үндсээрээ үрждэг бут ургамал, мал сайн иднэ); **улаан тулам** ургамал (хайрслаг хатуу навчтай олон наст ургамал, цэцэг том, уулын бэлээр ургана, ногоон байхад нь мал иднэ); **улаан толгой** ургамал (чийгтэй нуга газар ургадаг, үет ургамлын язгуурын ургамал; түрүү улаавтар, бүх төрлийн мал сайн иднэ); **улаан лууль** ургамал боловсорч гүйцсэн хойноо арьс нь час улаан өнгөтэй болдог, идэшний таримал ногоо амт амтайхан бөгөөд шүүслэг); **улаан манжин** ургамал (улаавтар өнгөтэй, том үндэс бүхий, идэшний таримал ногоо, амт амтайхан); **улаан лууван** ургамал (улаавтар үндэс бүхий таримал ногоо, амт гашуухан, үндсийг иднэ, навчийг мөн идэж болно); **улаан бургас** ургамал (удын нэгэн зүйл мод, бүдүүн нь эрхий хуруу хир, өнгө улаан, навч нь бургасны навчнаас өргөн болоод урт); **улаан уд** ургамал (дурс нимгэн, мах судал цэгээн, салааны үзүүр улаавтар, сумны иш зэрэгт хэрэглэнэ); **улаан зандан** ургамал (халуун оронд ургадаг мод, чанар хатуу, өнгө улаан, жил удсан хойно өнгө нь хүрэн болно, модны судал зурдастай, жил удаагүйг усанд дэвтээж юм будвал болно, бас эмнэлэгт хэрэглэнэ); **улаан чигийрмаа цэцэг** ургамал (хүйс эрхэм чигийрмаа цэцэгтэй адил болоод өнгө улаан, навч өргөхөн болоод зөөлөн цэцэг); **улаан салаат чигийрмаа цэцэг** ургамал (эрхэм чигийрмаа цэцгийн нам, нэг ишид тав-зургаан хүйс цэцэглэдэг цэцэг); **улаан сарт гогшуурга** амьтан (их бие хэрээний адил, өнгө цох хар, толгойдоо улаан сартай нэг зүйл тогшуурга шувуу); **улаан хушуут хэрээ** амьтан (хэрээтэй адил болоод хушуу хөл улаан, жигүүр сүүл хар болоод урт, төрөлх намхан нэг зүйл шувуу); **улаан бор азрага** амьтан (улаан чандартай, хар бидэр бүхий нэг зүйл бялзуухай, богширго гэнэ); **улаан болжмор** амьтан (хушуу улаавтархан шар, хоёр зажуурт цагаан чандар сагсайж ургана, жигүүр сүүл улаавтархан, тэрмийн өнгөтэй боловч цагаан чандар холилдсон нэг зүйл болжмор шувуу); **улаан хүзүүт** амьтан (хүзүү улаан, хушуу хар, толгойдоо урт чандар буй, хүнийг үзэж дуугарахад толгойн чандар нь сагсайж босдог нэг зүйл шувуу); **улаан туруу** амьтан (хушуу сүүл хар, бие улаавтархан бараан нэг зүйл хэрээ); **улаан дэлбэ** амьтан (шүд нохойн шүдтэй адил, том нь гурваас дөрвөн тохой, хушуу ээтгэр нэг зүйл загас); **улаан цогондой** амьтан (янз цогондой адил боловч ирвэс мэт бидэртэй, өнгө улаан, жил удвал ирвэс мэт болно, махаар идэш хийнэ); **улаан хөл** амьтан (биеийн чандар үнсэн өнгөтэй, аньсгын дээд талд цайвар шар чандар хөмсөгтэйгөө адил, шийр маш улаан нэг зүйл бялзуухай); **улаан гарди** амьтан (байдал төлөв тахиатай адил, үс нь таван өнгөтэй гоёмсог сайхан нэг зүйл шувуу); **улаан толгойт** амьтан (янз хидрүү бялзуухайтай адилхан, ар өнгө хөхөвтөрхөн, толгой улаан нэг зүйл бялзуухай); **Улаан нүдэн гариг** (Нарны аймгийн ертөнцийн нэгний нэр); **улаан шуурга** (цас бороогүй, шороо тавих их шуурга); **улаан салхи** (улаан шуурга); **улаан гэрэл** (явахыг хориглосон дохионы гэрэл); **улаан гол** (а. харвах дүгрэг байны дунд байдаг улаан цэг; б. хүн амьтны гол судал: в. маш хайртай); **улаан хоолой** (хүн амьтны идэш ууш залгих хоолой); **улаан сам** (буудайн гурилд бал хоршин зуурч цагаан самын ёсоор үйлдэж гахайн тосонд буцалгасан идээ); **улаан хагсмал боорцог** (жигнэсэн буудайн гурилд чихэр, нохойн хушууны ус хоршиж хайрсан идээ); **улаан өндөг** (Христос шашинтны хаврын баяр).

УЛААНУУД биеэр улаан бижрүү туулах хүүхдийн халдварт хижиг өвчин, корь, бага зэрэг сувилах ч гэнэ.

УЛААНТАН хуучирсан хувьсгалчдыг нэрлэж байсан нэр.

УЛААЧ улаа нэхэх хүн, улааг эгүүлэн бууцааж авах хүн.

УЛААЧЛАХ улаа нэхэх, улаачийн албан хаах.

УЛААЧЛУУЛАХ улаачлахын үйлдүүлэх хэв.

УЛАВЧ 1. гутлын уланд дэвсэх зүйл; *эсгий улавч; улавч дэвсэх;* 2. хавхны дор тавих зүйл; *хавхны улавч.*

УЛАГ I уршиг, балаг; **улаг балаг** х о р ш . .

УЛАГ II нөр, шунал ихтэй, шунамгай; *хэтэрхий улаг хүн.*

УЛАЙ мах цус болон улайж харагдах зүйл; *элээ хэрээ улай андахгүй;* **улай гарах** (сэг гарах); **улай удах** (улай гаргах, хийх); **улай хийх** (малыг олноор алж улай гаргах).

УЛАЙДАХ улай болгох; *дээлээ улайдах; гараа улайдах.*

УЛАЙДУУЛАХ улайдахын үйлдүүлэх хэв.

УЛАЙЛГАХ I улайхын үйлдүүлэх хэв, улаан болгох; *нүүрий нь улайлгах; нүүрээ улайлгах.*

УЛАЙЛГАХ II улайх III-ын үйлдүүлэх хэв, илрүүлэх, хүлээлгэх; *хэргий нь улайлгах.*

УЛАЙН: улайн цайн улаан, цайн, гүжир, хилс; *улайн цайн гүтгэх; улайн цайн мэлзэх.*

УЛАЙРАХ I улаан харагдах, баахан улайх; *тэнгэрийн хаяа улайрч байна;*

УЛАЙРАХ II махрах, мэрийх, чармайх, хамаг санаа сэтгэлээ тавих; *ажилдаа улайрах; тоглоомд улайрах;* 2. уурлаж яахаас ч буцахгүй болох, улайшрах; *улайрсан мэт дайрав; сарлагийн бух нэг улайрвал тун бэрхтэй шүү.*

УЛАЙРУУЛАХ улайрахын үйлдүүлэх хэв.

УЛАЙСАХ 1. галд халж улаан болох; *улайссан төмөр;* 2. хэтэрхий халуун болох; халах, цонох; *газар улайсах; дээврийн төмөр улайсах; энэ өдрийн халуунд улайсахад хүрэв.*

УЛАЙСГАХ улайсахын үйлдүүлэх хэв, улайсахад хүргүүлэх.

УЛАЙСХИЙХ баахан улаан, улбар болох.

УЛАЙТАХ I түлэгдэж, халж улаан болох, халах;

УЛАЙТАХ II улай болох.

УЛАЙТГАЛ улайтгах үйлийн нэр.

УЛАЙТГАХ улайтахын үйлдүүлэх хэв.

УЛАЙХ I улаан болох; *галд хийсэн төмөр улайв; тэнгэрийн хаяа улайх;* **царай улайх, нүүр улайх** (ичих, зовних).

УЛАЙХ II мэрийх, чармайх, махрах; *улайж байгаад ажлаа гүйцээж орхилоо.*

УЛАЙХ III үйлдсэн буруу хэргээ илчлэн хүлээх; *хулгайч, хэргээ тодорхой улайжээ; хуурч мэхэлснээ улайв.*

УЛАЙШРАХ улайх, улайрах, мэрийх, зүтгэх, шамдах, чармайх; *хийж байгаа ажилдаа улайшрах.*

УЛАЙШРУУЛАХ улайшрахын үйлдүүлэх хэв.

УЛАЛЖ у р г а м а л хотгор газар ургадаг иш өндөр нэг зүйл өвс; **улалж салбах** (улалжийг урт иштэй хадуураар цавчиж авах); **улалжийн гэр** х у у ч и р с а н (гэрээ муушаах үг).

УЛАЛЗАХ галын дөл байн байн улааран харагдах, улбалзах; *гал улалзах; улалзаж харагдах;* **нүүр улалзах** (уур хилэн төрснөөс болж нүүр царай байн байн улаан болох).

УЛАЛЗУУЛАХ улалзахын үйлдүүлэх хэв.

УЛАМ 1. нэн, хэт, хэтэд; *улам нэмэгдэх; бороо улам ширүүсэв; улам ихсэх; улам дордох;* 2. харгаа; *хэлэлцсэний улмаас; мэдэхийн улмаас тийм болжээ.*

УЛАМЖИЛЛАГА уламжлал.

УЛАМЖЛАЛ залгамжлан авах, уламжлах зүйл; *манай ард түмний эртний уламжлал; уламжлалын зарчим; манай ард түмэн баатарлаг уламжлалтай билээ.*

УЛАМЖЛАЛТ уламжлал бүхий; *уламжлалт соёл; уламжлалт үг; уламжлалт баяр* наадам.

УЛАМЖЛАХ 1. залгамжлан авах, залгамжлах; *эртнээс уламжилсаар ирсэн заншил;* **үе улиран уламжлах** (үеэс үед дамжуулан авах); 2. цааш дамжуулах, дээш нь дамжуулах; *уламжлан мэдэгдэх; бичгээр уламжлах; та уламжилж өгнө үү; сумын захиргаагаар уламжлан явуулах.*

УЛАМЖЛУУЛАХ уламжлахын үйлдүүлэх хэв.

УЛАМЛАХ уламжлах, санаа авах; *таны хэлснээс уламлан бодоход; уламлан сурвалжлах; уламлан мөрдөх.*

УЛАМЛУУЛАХ уламлахын үйлдүүлэх хэв

УЛАНГАСАХ 1. улайрах, улайшран санаашрах; *цус хараад улангасах; улай үзээд улангасах;* 2. өлсөж цангаж уух идэхийг мэрийж улайрах; *улангассан чоно; улангассан юм шиг ус залгилав.*

УЛАНГАСУУЛАХ улангасахын үйлдүүлэх хэв.

УЛАНГИР нүдний салст бүрхэц үрэвсэх өвчин.

УЛАНГИРТАХ улангир өвчин тохиолдох.

УЛАР а м ь т а н ойд оршино, хур гургуултай адил болоод том, үнсэн өнгөтэй, сүүл урт нэг зүйл шувуу.

УЛАСХИЙЛГЭХ уласхийхийн үйлдүүлэх хэв.

УЛАСХИЙХ гялсхийх, түргэн зуур улайх; *чийдэн уласхийгээд унтрав; гэрэл уласхийв;* **нүүр уласхийх, царай уласхийх** (түргэн зуур улайх).

УЛБАА I чийг бууж өвс ургамлын дээр хуралдан тогтсон ус.

УЛБАА II 1. чийр зам; *малын улбаагаар ороод яв;* 2. ураг төрлийн сүлбээ; **улбаа сүлбээ** х о р ш . : 3. сураг танаг; *улбаагий нь мөшгөөд бай, чингэвэл нэг юманд хүрэх биз.*

УЛБАГАНАХ улбагар юмны үргэлжлэн хөдлөх.

УЛБАГАНУУЛАХ улбаганахын үйлдүүлэх хэв.

УЛБАГАР 1. яс чанар муу, улцгар, сиймхий; *улбагар торго; улбагар амттай хоол;* 2. тэнхэл тамир дорой, сул; *улбагар биетэй хүн.*

УЛБАЙЛГАХ улбайхын үйлдүүлэх хэв, улбагар болгох.

УЛБАЙХ улбагар болох.

УЛБАЛЗАХ I 1. улаан өнгөтэй юмны дэрвэж хөдлөх, улалзах; *гал улбалзав;* 2. ш и л ж с э н нүүр царай гэнэт гэнэт улайх; *уурлаж улбалзах.*

УЛБАЛЗАХ II улбагар юмны байн байн хөдлөх.

УЛБАЛЗУУЛАХ улбалзахын үйлдүүлэх хэв.

УЛБАР улаан өнгөнд шар өнгө өчүүхэн хольцонгуй нь, эсэхүл шар өнгөнд улаан өнгө эчүүхэн хольцонгуй нь; *улбар шар;* **улбар бор** (хүрэн улаанаас баахан буурай өнгө); **улбар бялзуухай** (улаан богшрого шувуу); **улбар шувуу** а м ь т а н (а. хушуу хар болоод үзүүр нь матаастай, өд чандар улбар нэг зүйл шувуу; б. хээрийн галуу); **улбар аргуй** у р г а м а л (иш богино болоод үсэрхэг, цэцгийн өнгө нь улбар хөх нэг зүйл цэцэг).

УЛБАР II: **улбар ядах** өр өвдөх, нигүүлсэн тэсч ядах.

УЛБАРАХ улбагар, зөөлөн, улцгар, сиймхий болох.

УЛБАРИХ 1. улиран хувилах; 2. ш и л ж с э н санаа сэтгэл хувирах.

УЛБАРИУЛАХ улбарихын үйлдүүлэх хэв.

УЛБАРУУЛАХ улбарахын үйлдүүлэх хэв.

УЛБАС I 1. маш зөөлөн, талх хэмхдэг болсон нь; **улбас болох** (маш зөөлөн болох, маш нунтаг хэмхдэг болох); 2. маш яданги; **улбас болтол нүдэх** (их л жанчих); 3. ш и л ж с э н давтан давтан; **улбас болтол өгүүлэх** (давтан давтан өгүүлэх).

УЛБАС II: **улбас улбас хийх** улаан гэрэл, гал байн байн асах.

УЛГҮЙ 1. ул байхгүй; *улгүй түрий байна;* 2. ш и л ж с э н сууригүй, суурь муутай, хөнгөн, хийсвэр, хуумгай; *улгүй хөдөлж болохгүй; улгүй хэрэг бүү үйлд.*

УЛДАХ малын туурай, таваг элэгдэж гишгэхдээ эмзэглэх болох; *улдсан морь; тэмээ улдах.*

УЛДУУЛАХ улдахын үйлдүүлэх хэв.

УЛЖГАР улхгар, улбагар, сул; *улжгар биетэй хүүхэд; улжгар ястай эд.*

УЛЖИЙХ улжгар болох.

УЛЖИХ дөнгөж амьдрах; *амь улжих; өл залгаж улжих.*

УЛИА улимтгай, ульдаг.

УЛИАН нохойг хараах үг

УЛИАНГАР у р г а м а л улиасны нэг төрөл, өндөр ургадаг мод, голын шугуй ба чийгтэй газар ургана, цайвар саарал дурстай.

УЛИАС у р г а м а л бургасны төрлийн навчит мод, өндөр ургана.

УЛИГ 1. яршиг, азад; *улиг домог болсон зүйл;* **улиг болох** (байн байн хэлж азад болох); 2. уршиг, будлиан; **улигт торох, улигт чирэгдэх** (хэрэгт чирэгдэх).

УЛИГЛАХ улиг болох, дахин давтан яриглан хэлэх, шаардах.

УЛИГЛУУЛАХ улиглахын үйлдүүлэх хэв.

УЛИГТ улиг бүхий; *улигт хэрэг; улигтыгаа домоглоё.*

УЛИНГАР зөөлөн хөрстэй өвс ногоо сахлаг ургах газар; *улингар газар; улингар хөрс.*

УЛИНХАЙ сэг, улай.

УЛИРААХ улирахад хүргүүлэх, улируулах; *анги улираах; цаг улираах; өдөр сар улираах.*

УЛИРАЛ улирах үйлийн нэр: 1. хавар, зун, намар, өвөл буюу жилийн дөрвөн цагийн аль нэг нь; **цаг улирал** х о р ш.; *атрын сангийн аж ахуйд очоод таван жил болоход цаг улирал ээлжлэн хувирсаар байв; зуны улирал;* **дөрвөн улирал** (хавар, зун, намар, өвөл); **хүйтний улирал** (хүйтэн цаг); **дулааны улирал** (дулаан цаг); **улирлын ажилчин** (үргэлж биш, ямар нэгэн улиралд ажиллах ажилчин); 2. жилийн арван хоёр сарыг гурав гурваар хуваасны нэг нь; *гуравдугаар улирлын төлөвлөгөө;* **хуучин улирал** (Дорно зүгийн зурхайн он тоолол); **билгийн улирал** (сарны явдлыг баримталсан зурхайн ёсны тоолол); **аргын улирал** (нарны явдлыг баримталсан зурхайн он тоолол); **шинэ улирал** (Европ зүгийн зурхайн он тоолол).

УЛИРАХ 1. өнгөрөх, нөхцөх; *цаг улирах тутам;* **улирсан, завхарсан** (өнгөрсөн, завхарсан); 2. хийж байсан хугацаат ажил үйлийг хугацаа сунган хийх; *тушаалд улиран ажиллах; улиран сонгогдох;* **анги улирах** (анги дэвшихгүй, хуучин байсан ангидаа суралцах); **улиран хувьсах** (алив юм урт удаан хугацаанд аажмаар хөгжиж тооны хувьслаас чанарын хувьсал болох); **үе улирах** (алив шинж чанар, юм үе залгамжлан ирэх; *үе залгамжлан оршин суусаар ирсэн нутаг).*

УЛИРУУЛАХ улирахын үйлдүүлэх хэв.

УЛИУЛАХ улихын үйлдүүлэх хэв.

УЛИХ чоно нохой зэрэг зарим амьтны урт удаанаар гэншиж гингэнэн дуугарах; *чоно улих сонсдох мэт болов; нохой улих.*

УЛЛАА гутал уллах бүдүүн утас.

УЛЛАГА уллах үйлийн нэр; *уллага сайтай гутал байна.*

УЛЛАХ I 1. гутал, оймс мэтэд ул хийх; *гутал уллах; оймс уллах;* 2. гутлын улаар газар гишгэн цахалж татах; *уллаж суух;* 3. ш и л ж с э н суурьтай зан гаргах, хашир догь зан гаргах; **уллах суурилах** х о р ш.; *нилээд уллаж үзэх нь чухал.*

УЛЛАХ II тэмүүлэх.

УЛЛУУЛАХ уллахын үйлдүүлэх хэв, ул суурьтай болгох.

УЛС I 1. нэгэн орны ноёрхох ангийн эрх ашгийг хамгаалсан зохион байгуулалт бүхий орон, гүрэн: **улс төр, улс гэр** х о р ш.; *Бүгд Найрамдах Монгол Ард Улс; Зөвлөлт Холбоот Улс; Бүгд Найрамдах Хятад Ард Улс; бүгд найрамдах улс; холбооны бүгд найрамдах улс;* **улс төрийн бодлого** (улсаас дотоод гадаадын бүх асуудлын талаар явуулах үйл ажиллагаа); **Улсын их хурал** (Бүгд Найрамдах Монгол Ард улсад: төрийн дээд эрхийг барих төлөөлөгчдийн хурал; *Улсын Их Хурлын Тэргүүлэгчид*); **улсын далбаа** (төрийн далбаа); **улсын сүлд** (төрийн сүлд); **улсын дуулал** (төрийн дуулал); **улсын хөрөнгө** (албаны хөрөнгө); **улсын гүнж** х у у ч и р с а н (хааны төрсөн охин); **улсын тавнан** х у у ч и р с а н (улсын гүнжтэй ураг холбосон эр); **улсын судар** (нэгэн төрийн хэрэг явдлыг тэмдэглэсэн бичиг; *Юань улсын судар*); 2. хүн; *талбайд бааханулс цугларсан байв; манайд хэдэн улс ирсэн; тэртээгээс морьтой улс айсуй явна.*

УЛС II үсийг зулгааж зумласан, буга зүр зэрэг гөрөөсний арьс.

УЛСХИЙХ улаан өнгө хоромхон зуур үзэгдэх; *гал улсхийх; царай улсхийх.*

УЛУУ хулуу, хуян.

УЛХАЙЛГАХ улхайхын үйлдүүлэх хэв, улхгар болгох.

УЛХАЙХ улхгар болох, улбайх.

УЛХАЛЗАХ улхгар юмны улхас улхас хөдлөх.

УЛХГАНАХ улхгар юмны улхга улхга хөдлөх.

УЛХГАР 1. яс чанар муу, улбаагар, улцгар; *улхгар торго; улхгар даавуу;* 2. ш и л ж с э н амт сул, муу; *давсгүй улхгар амттай;* 3. ш и л ж с э н ядуу дорой, тамир чадал муу; *улхгар сул биетэй.*

УЛЦАЙЛГАХ улцайхын үйлдүүлэх хэв, улцгар болгох.

УЛЦАЙХ 1. улцгар болох; 2. хүүхэд эмгэглэж бие нь сулрах; *хүүгийн бие баахан улцайгаад л байна.*

УЛЦАЛЗАХ 1. улцгар юмны улцас улцас хийж хөдлөх; *үйланхай мэт улцалзах;* 2. улцан юмны хөдлөх, аашлах; 3. улцвалзах.

УЛЦАН нулимс гоожимтгой; *улцан нүд.*

УЛЦАР: улцар өвчин нүдний халдварт ужиг өвчин.

УЛЦВАЛЗАХ 1. улцалзах; 2. улцан амьтны хөдлөх, аашлах.

УЛЦГАНАХ 1. улцгар юмны улцга улцга хийх; 2. улцан юмны хөдлөх, аашлах.

УЛЦГАНУУЛАХ улцганахын үйлдүүлэх хэв.

УЛЦГАР 1. нойтон, улхгар; *улцгар нясуу; улцгар нус; улцгар нүд;* 2. ш и л ж с э н яс чанар муу, сиймгэр нимгэн; *улцгар дурдан.*

УЛЦРАН улцар өвчнөөр өвдсөн хүн.

УМАЙ эмэгчин амьтны үр хээл торниж биелэх дотоод эрхтэн, сав; *эхийн умай.*

УМАЙЛГАХ умайхын үйлдүүлэх хэв, умгар болгох.

УМАЙХ 1. умгар болох; *онгойж явахаар умайж яв гэсэн юм* з ү й р; 2. хорчийж атирах; *дээлийн дотор түлэгдэн умайжээ.*

УМАЛЗАХ умгар юмны байн байн хөдлөх.

УМАЛЗУУЛАХ умалзахын үйлдүүлэх хэв.

УМАР хойт, хойт зүг; *умар зүгт орших их Зөвлөлт Орос Улс.*

УМАРД умар; **умард туйл** (дэлхийн бөмбөрцгийн хойт этгээд наядугаар өргөргөөс цааш бүхий орчин).

УМАРТАХ б и ч и г мартах.

УМАРТУУЛАХ умартахын үйлдүүлэх хэв.

УМАРХИ умрынх.

УМБАГАР 1. маш зөөлөн; 2. тумбагар.

УМБАХ 1. усанд орох, шунгах, сэлэх, шумбах; *усанд умбах;* 2. ш и л ж с э н элбэг идээ ундаан, торго тамсгийг дураар хэрэглэх, эдлэх; *тосонд умбах; торгонд умбах.*

УМБУУЛАХ умбахын үйлдүүлэх хэв.

УМГАР 1. хуньж өмгөр, бяцхан болсон нь; *умгар хүүдий; умгар сав;* 2. ам амсар, нүх мэтийн өмгөр, бяцхан; *умгар амтай ваар; умгар аманд банш багтахгүй.*

УМД унд.

УМДАГ 1. хэвлийн доод этгээдэд байх овгор газар; **умдаг яс** (мөн тэнд байх яс): 2. зассан малын хуухны орчин газар, хуухнаг.

УМЗАД унзад.

УМРАХ өмрөх, хялбархан урагдах.

УМС адууны бүдүүн гэдэс.

УМШ дарины ширхэг.

УМШЛАХ дарийг ширхэглэх.

УНАА уналга, унах хөсөг; **унаа унаш** х о р ш.; *унаа морь; чи ямар унаатай явааа вэ, машинтай юу?* **унаа юүлэх** (уналга сольж өөрчлөх); **ганц унаатай** (нэг л унах юмтай); **унаа сайтай** (унах юм олонтой); **унаа муутай** (унах юм цөөнтэй); **унаанд муу** (морь унахдаа муу); **унаанд сайн** (морь унахдаа чадамгай).

УНААЖИХ унаатай болох.

УНААЖУУЛАХ унаажихын үйлдүүлэх хэв, унаатай болгох.

УНААРХАХ унаатайгаа гайхуулах.

УНААСАГ унаа унахдаа их дуртай.

УНААШРАХ морь мал, унаанд удаж ядарч зүдрэх; *морь унаашраад муухай ааштай болжээ.*

УНААШРУУЛАХ унаашрахын үйлдүүлэх хэв.

УНАГА (Н) 1. адуу, хулан, тахь зэргийн амьтны нэг настай төл; *унагатай гүү;* **унаган жороо** (төрөлх жороо); **унага орхих, унага хаях** (гүү сар гүйцээгүй унагалах); **унага хөндөлсөх** (гүүний хэвэл дэх унага бэхжих); *хүн болох багаасаа, хөлөг болох унаганаасаа* з ү й р; 2. ш и л ж с э н язгуурын, угийн; **унаган дэл** (унаган цагаас эхлэн аваагүй дэл); **унаган морь** (өөрийн адуунд төрсөн морь); **унаган албат** х у у ч и р с а н (язгуурын жинхэ-

нэ албат); **унаган боол** хуучирсан (Чин улсын үед нэгэн үе болсон боолыг ийнхүү нэрлэж байжээ); **унаган түрүү** ургамал (хайлс модны нахиатай адил болоод усанд хөвж ургадаг нэг зүйл өвс); **унаганы түрүү** ургамал (замагтай адил болоод усанд хөвж ургадаг нэг зүйл өвс); **унаганы шийр** ургамал (хээр талд ургадаг, шар цэцэгтэй, навч морины туурайтай төстэй ургамал, эмнэлэгт хэрэглэнэ).

УНАГААЛГАХ унагаахын үйлдүүлэх хэв, унагаахад хүргүүлэх.

УНАГААХ унагахын үйлдүүлэх хэв, унагахад хүргүүлэх; **харгис төрийг унагаах** (харгис төрийг устгах); **нулимс унагаах** (уйлах); **төлбөрт унагаах** (төлбөртэй хэрэгт оруулах); **ял унагаах** (яллах).

УНАГАЛАХ I гүү унага төрүүлэх; *гүү унагалах.*

УНАГАЛАХ II юмыг зэрэг зэрэг унагах.

УНАГАХ I. унахын үйлдүүлэх хэв; 2. оёсон оёдлыг хажуу тийш даран нааж илүүрдэх; *дээлийн хажлага унагах;* 3. ял хэрэг ногдуулах; *ял унагах;* 4. гэмт хэрэгт холбогдуулах, оруулах; *хэрэгт унагах.*

УНАГУУЛАХ унагахын үйлдүүлэх хэв.

УНАДАГ I 1. унадаг юм; *унадаг дугуй;* 2. унамтай; *унадаг тэмээ.*

УНАДАГ II: **унадаг өвчин** татганан ухаан алдаж ойчдог, мэдрэлийн өвчин.

УНАЛ унах үйлийн нэр, уналт.

УНАЛГА унаа, хөсөг; *уналга морь; уналга машин.*

УНАЛТ 1. унах үйлийн нэр, унах явц; 2. аж амьдрал, санаа сэтгэлийн доройтолт; *унатад орох;* 3. сөнөлт, мөхөлт.

УНАМГАЙ унуулж сурсан, унахад болох; *унамгай тэмээ; унамгай сарлаг.*

УНАНГИ 1. унаж ойчсон нь; *унанги мод;* 2. дархи, унууль.

УНАХ I 1. ойчих; **унах дусах** хорш.; *шат дээрээс унах; салхинд унасан мод; барилдаад унах;* **цас унах** (цас орох); **унан тусан хүрч ирлээ** (арай хийж явж ирлээ); 2. муужрах, доройтох, ухаан алдан үхэтгэх; *муужран унах; санаа сэтгэлийн талаар унах; ажил нь унаад удсан газар байна; энэ хүн шуугиан үймээнтэй газар унаад байдаг болсон юм.*

УНАХ II мордох, зайдлах, суух; *морь унах; дугуй унах; машин унах; мод унах; унаж суух.*

УНАЦ өвс ногооны гарц, ургац; *өвсний унац сайн байна.*

УНАЧИХ ойчих.

УНАШ: унаа унаш уналга, унаа.

УНГАЛДАХ 1. адууны янцгаах; *морь унгалдах сонсдов;* 2. зарим амьтны дуугарах; *элээ унгалдах.*

УНГАЛДУУЛАХ унгалдахын үйлдүүлэх хэв.

УНГАЛИХ 1. хүчдэн амь тэмцэх; 2. амьсгал давхцах.

УНГАРАГ унгамтгай.

УНГАРИЛ 1. мал адгуусны нарийн ноос, хөөвөр, ноолуур, зөөлөн ширхэгтэй юм; **зөөлөн унгарил** хорш.; 2. шувууны чандар, өрөвлөг; 3. ургамлын хөвөн.

УНГАС I ноос; *тэмээний унгас; хонины унгас;* **унгас савах** (ноосыг саваагаар дэлдэлхийлэх); **унгас нумдах** (ноосыг хөвчдөх); **унгас урах** (ноосыг сэмчих).

УНГАС II амьтны гэдэснээс гарах хий.

УНГАСАХ I унгатах.

УНГАСАХ II 1. үр хүүхэд зэрэгт өхөөрдөн янаглах, янаглан өхөөрдөж дуугарах; 2. гүүний унагандаа үүрсэх; 3. үнээ малын тугалдаа тэмүүлэх.

УНГАСУУ унгасамтгай; *хүүхэддээ унгасуу.*

УНГАТАХ унтрах шахсан галд хийсэн аргал зэрэг юм асч эхлэх, унгасах; *гал унгатах.*

УНГАТГАХ унгатгахын үйлдүүлэх хэв, асаах; *гал унгатгах.*

УНГАХ хэвэл доторхи хий доош гарах.

УНГУУЛАХ унгахын үйлдүүлэх хэв.

УНД уух юм, ундаан; **цай унд, хоол унд, унд шингэ** хорш.; *унд уух; унд шингээ уух; сэрүүн унд; халуун унд; хоол унд сайтай яв!*

УНДАА хөөсрүүлж исгэсэн шингэн хоормог.

УНДААН унд; **идээн ундаан** хорш.; **хөлчүүрүүлэх ундаан** (архи дарс зэрэг согтоох ундаан).

УНДААСАХ цангах, юм уухыг хүсэх; **цангах ундаасах** хорш.

УНДААСГАЛАН ундаассан, цангасан нь.

УНДАРГАХ ундруулах, ундархад хүргүүлэх.

УНДАРЛАГА ундарч байгаа юм; *усны ундарлага; аршааны ундарлага.*

УНДЛАХ унд уух; *ажилд явахдаа сайн ундалж яваарай.*

УНДЛУУЛАХ ундлахын үйлдүүлэх хэв.

УНДРААХ ундрахад хүргүүлэх, ундруулах.

УНДРАГА I усны ундран гарах нь; *усны ундрага; ундрага сайтай худаг.*

УНДРАГА II алт мөнгөн од бүхий шил мэт зүйл, чимэглэлд хэрэглэнэ.

УНДРАЛ 1. ундрага I; 2. үл шавхагдах зүйл; *соёлын ундрал.*

УНДРАМ ундрага II.

УНДРАХ 1. булгийн усны сэггүй үргэлжлэн гарах; *ундрах булгийн ус мэт;* 2. шилжсэн ямар нэгэн юмны үргэлжлэн өрнөх, бадрах; *ерөөлчийн сэцэн үг ундрах мэт хүвж байв; ажил хөдөлмөр ундарсан орон;* **хэрэг ундрах** (хэрэг түвэг гэнэт үүсэн үргэлжлэх).

УНДРУУЛАХ ундрахын үйлдүүлэх хэв.

УНДСАХ унд хүсэх, ундаасах.

УНДУЙ: ундуй сундуй эмх журамгүй; **ундуй сундуй орхиж одох** (яарч сандран, юм хумаа задгай тархай орхиж явах).

УНЖГАЙ 1. унжсан байдалтай, унжгар; 2. зуурaлдсан байдалтай.

УНЖГАНАХ унжгар юмны үргэлжлэн унжин санжин хөдлөх.

УНЖГАНУУЛАХ унжганахын үйлдүүлэх хэв.

УНЖГАР 1. доош унжсан нь; *унжгар цэцэг;* 2. шилжсэн дорой, нунж, царай зүс муу, тэнхээ тамир муу; *унжгар царайтай; унжгар биетэй;* **унжгар уд** ургамал (салаа навч доош унжиж ургасан нэг зүйл уд мод); **унжгар хайтан цэцэг** ургамал (иторын адил унжиж цэцэглэх бөгөөд цэцгийн иш нарийн урт нэг зүйл цэцэг).

УНЖИЙЛГАХ унжийхын үйлдүүлэх хэв.

УНЖИЙХ 1. унжгар болох, уртхан унжих буюу удаан унжих; 2. тэнхээ тамиргүй, дорой байх; *чи чинь өнөөдөр яагаад унжийж орхив?*

УНЖИЛЗАХ унжгар юмны байн байн унжих.

УНЖИН: унжин санжин энд тэндгүй унжсан нь.

УНЖИР: унжир санжир унжсан санжсан юм; *минийн дээл урагдаж унжир санжир болж орхив;* **унжир санжир явах** (арай чарай явах).

УНЖИХ дээрээс доош дүүжлэгдэн санжиж байх; *бүс чинь унжиж байна; усан үзэм унжих; өрхний оосор унжих.*

УНЖЛАГА 1. унжуулсан юм; *унжлага чимэг; унжлага зүүлт;* 2. утас зэргээс юм дүүжилж чиг хэмжих хэрэгсэл; **унжлага цэцэг** ургамал (унжгар удын найлзуур мэт гулжилзсан тогтуургүй, өнгө шаравтар ногоовтор хоёрын хооронд, анхилам сайхан үнэртэй нэг зүйл цэцэг).

УНЖРАХ удаашрах, хэтэрхий удаан болох; *энэ жүжгийн төгсгөл хэтэрхий унжрах магадгүй болжээ; унжирсан үл барагдах явдал.*

УНЖРУУЛАХ унжрахын үйлдүүлэх хэв.

УНЖУУ 1. доош унжсан, хэтэрхий дор болсон нь; *унжуу энгэр; унжуу хормой;* 2. нуршуу удаан.

УНЖУУЛАХ унжихын үйлдүүлэх хэв.

УНЖУУРГА 1. унжиж байх зүйл; 2. дайвар, дагавар, нэмэлт; 3. шилжсэн ямар нэгэн сэтгэлийн үлдэц, хоцоргол; *унжуурtай болох.*

УНЗАД шашны хурал номын, ном уншлага эхлэх бүдүүн дуутай хүн: **унзад хоолой** (бүдүүн дуутай хоолой).

УНИАР газрын чийгт уур дээш дэгжиж, утааны адил хөөрөн тархах нь; **утаа униар** хорш.; *униар манан; хөх униар татах; ногооны униар.*

УНИАРТАХ униар татах, униартай болох; *униартан харагдах тэр хөндий, учирсан тэр минь нутагладаг.*

УНИАРТУУЛАХ униартахын үйлдүүлэх хэв.

УНИВЕРСИТЕТ их сургууль.

УНТАА унтаж байгаа; *унтаа дээрээ эс мэдэв.*

УНТАРГАХ унтраах.

УНТАРШГҮЙ унтрах аргагүй, унтрахад бэрхтэй.

УНТАХ нойрт эзлэгдэн байх; *унтах цаг болов; хэвтэж байгаад унтаж хоцорчээ; унтах тасалгаа.*

УНТЛАГА унтах нь; *унтлагын цаг болов.*

УНТРААГУУЛ унтраах хэрэгсэл; *гал унтраагуул.*

УНТРААЛГА цахилгаан гүйдлийг гүйлгэх зогсоох хэрэгсэл; *чийдэнгийн унтраалга.*

УНТРААЛГАХ унтраахын үйлдүүлэх хэв.

УНТРААХ унтрахад хүргүүлэх.

УНТРАХ 1. гал, гэрлийн мөхөх, ноцохыг болих; *шөнө гэрэл унтрав; гал унтрах;* 2. дарагдах, намжих; *өнөөх хэрэг унтарчээ; ажил унтарч гүйцэв.*

УНТУУ уур хилэн төрсөн байдал илрэн мэдэгдэх нь; **уур унтуу** х о р ш.; **унтуу гаргах** (унтуурсныг арилгах, гаргах).

УНТУУЛАХ унтахын үйлдүүлэх хэв; *ур хүүхдээ унтуулах; унтуулах эм.*

УНТУУРАХ анчны зоргүй, азгүй болох, буруны баарах.

УНТУУРХАХ унтууцах.

УНТУУЦАХ баахан уурлах, хилэгнэх, унтуурхах.

УНТУУЦУУЛАХ унтууцахын үйлдүүлэх хэв.

УНУУЛАХ унахын үйлдүүлэх хэв; *морь унуулах.*

УНУУЛЬ унанги; ☆ **унууль гүүр** (хотын хаалганы тушаахь гүүр).

УНУУШ морины сайвар жороо мэт, унахад зөөлөн эвтэй явдал; *унууштай морь.*

УНХИГҮЙ зүйг олохгүй, мулгуу, дорой.

УНХАЙХ унхгар болох.

УНХГАР бие байдал уруу дорой.

УНХИЛАХ 1. нялх малын хөх тэжээл зэргийг ээрч юм үмхлэх, нудчих; 2. эр амьтны эмэгчнийг хүсэн ээрэх;

УНШААЧ уншихдаа чадамгай.

УНШИГЧ уншдаг; *уншигчдын эвлэлгөөн хийв; уншигчдын бага хурал; номын санд ном уншигч хүмүүсийн тоо олшров.*

УНШИХ 1. ном бичгийг танин чанга дуугаар буюу чимээгүй дотроо дуудах; *ном унших; шүлэг унших; дуугарч унших; чанга унших; шивнэж унших;* 2. үзэх ном бичиг; *бага сургуулийн унших хэвлэгдэн гарав; унших ном; унших бичиг.*

УНШИЦГААХ уншихын олноор үйлдэцгээх хэв, зэрэг зэрэг унших.

УНШЛАГА унших үйлийн нэр; *уншлага явуулах; нийтийн уншлага; хүүхдийн уншлага;* **уран уншлага** (шүлэг, ёгт үлгэр мэтийг тод сайхан аялгуулан унших уншлага); **уншлагын газар** (уншлагын танхим); **уншлагын танхим** (номын сангийн номыг авч унших газар); **сонин уншлага** (сонины тоимыг уншиж, ярих зэргээр олонд танилцуулах нь).

УНШУУЛАХ уншихын үйлдүүлэх хэв; *ном уншуулах; сонин уншуулах.*

УНШУУШТАЙ уншиж үзүүштэй, эрхбиш уншвал зохих зүйл; *уншууштай ном.*

УНЬ 1. гэрийн хана дээр бөгсийг тогтоон бэхэлж, тооныг зүг бүрээс үзүүрийн углуураар тогтоох урт урт моднууд; 2. байшин саравчны нуруу, хавирга нуруунд ташаалж тавих адрыг тоссон нарийн мод.

УР (АН) I 1. урлах чадвар; **ур дарх** х о р ш.; *гартаа уртай хүн;* 2. нарийн гоёмсог янз; *ур сайтай хатгамал;* **уран зохиол** (хүн, юм, үйл явдлын дүр шинжийг үгээр илрүүлдэг нэг зүйл урлаг; *уран зохиолын цомролог);* **уран зохиолч** (уран зохиолыг зохиож бичигч; *Монголын уугаан уран зохиолч Дашдоржийн Нацагдорж);* **уран сайхан** (урлагийн зарим хэсэг; *уран сайхны кино; ардын уран сайхан; уран сайхны ажилтан нар);* **уран сайханч** (уран сайхны ажилд оролцогч); **уран зураг** (хавтгай юманд алив юмны төрх байдлыг гарган хийсэн дүрс); **уран зурагч** (уран зурагт мэргэжсэн хүн); **уран баримал** (юмны дүрс хэлбэрийг сийлэх, цутгах, барих зэргээр үйлдэн бүтээх нэг зүйл урлаг); **уран барималч** (уран барималд мэргэжсэн хүн); **уран бүтээл** (урлагийн талаар хийж бүтээсэн бүтээл); **гарын уртай** (гартаа дүйтэй); **уран хүн** (нарийн гоёмсог юм хийж чаддаг хүн; *мөнгөн хэт хутга хийдэг уран хүн);* **уран хуруу** (долоовор хуруу); **уран арга, уран мэх** (юм хийх үйлдэх,

санах болоход гаргах зөв зүйтэй мэргэн арга ухаан); **уран үг** (а. бичих, өгүүлэхэд хэрэглэх эвтэй, найртай сайхан үг; б. гоёч, хуурамч үг; *уран үгээр улсыг хуурах, усан балингаар лусыг хуурах* зүйр); **уран хараацай** амьтан (хараацайн нам, жигүүр сүүлийн уг этгээд улаавтархан шавар бөөрөнхийлж гоёмсог үүр хийдэг нэг зүйл хараацай шувуу); **уран шувуу** амьтан (богшрогын намын шувуу, бие бяцхан, өнгө боровтор, улиас болон бусад модонд үүрлэнэ, модны мөчирт авирахдаа их сайн, нисэхдээ хурдан, зуны цагт хорхой шавьж, өвөл үр ургамал иднэ, үүрээ төлөв усны хөвөөнд бий модны мөчирт дүүжлэн барих бөгөөд тэр нь их луран): **уран хажин** амьтан (толгойн өнгө улбар, хөмсөг цагаан, өвөгтэй, хоёр жигүүрийн өдний өрөвлөг дээш сөрөн ургадаг, эр эм ямагт хамт явдаг нэг зүйл нугас).

УР II бие махбодид товойж гарах цулцан; *хацар дээрээ уртай хүн; уртай мод.*

УРАГ 1. худ худгуйн хамаатан; **ураг төрөл, ураг садан** хорш.; *ураг садны хол нь сайн, ус аргалын ойр нь сайн* зүйр; **ураг элгэн** (бүх хамаатан цөм); **ураг тогтох** хуучирсан (а. хоёр этгээд хөвгүүн охин хоёроо эр эм болгохоор хэлэлцэж тохирох; б. эхийн умайд үр тогтох); **ураг бололцох** (эр эмийг холбож худ худгуй болох); **ураг удам** (хүн амьтны уг угсаа); 2. эхийн умайд бий болох үр хээл; **ураг унагаах, ураг хөндөх** (дутуу хөнгөжих); 3. эрэгчний төмс.

УРАГДАХ урахын үйлдэгдэх хэв; *дээл урагдах.*

УРАГЛАХ ураг болох, бөлолцох.

УРАГЛУУЛАХ ураглахын үйлдүүлэх хэв.

УРАГСАХ урагт элэгсэх, хамаасах, хайрлах, хичээнгүйлэх санаа гүйцэтгэх.

УРАГШ өмнө зүгт, урд зүгт; *урагшаа харах; урагшаа явах;* 2. давших зүг өөдөө, ухралгүй, чигээрээ; *урагшаа алхах; урагшаа давших;* 3. урьд, тэргүүнд; *үүр гэгээрэхээс урагш харанхуй байдаг;* 4. шилжсэн бүтэл, бүтэмж, амжилт; *урагш муутай үг сонсох.*

УРАГШГҮЙ өөдгүй, бүтэлгүй, чадваргүй; *урагшгүй амьтан; урагшгүй ажил болов; урагшгүй ноёнд ухаангүй албат учрах* зүйр.

УРАГШДАХ хэтэрхий урагш болох.

УРАГШДУУЛАХ урагшдахын үйлдүүлэх хэв.

УРАГШИД үүнээс урагш, цаашид; *урагшид хичээнгүйлэн явсугай!*

УРАГШИХ урагш бий, урагш орших.

УРАГШЛАХ 1. өмнө зүг рүү явах; 2. урагшаа явах; *нэг алхам урагшлах хэрэгтэй;* 3. шилжсэн ажил үйл бүтэх, бүтэмжтэй байх.

УРАГШЛУУЛАХ урагшлахын үйлдүүлэх хэв; *хугацаа урагшлуулах.*

УРАГШТАЙ бүтэмжтэй; *миний ажил урагштай сайн байна.*

УРАЙ цэргийн дайрах болон ерөөс цог жавхлантайг үзүүлэхэд дуудан хашгирах үг; *урай хашгиран дайрах; урай хийх.*

УРАЙЛАХ урай гэж хашгирах.

УРАЙЛУУЛАХ урайлахын үйлдүүлэх хэв.

УРАЛГУУ 1. зөөлөн аятай; **уралгуу нум** (аятай сайн нум;) 2. морины жолоо дагуу зөөлөн эвлэг.

УРАЛДААЛАХ уралдах.

УРАЛДААН уралдах нь; *морины уралдаан; хүүхдийн уралдаан; явган уралдаан; дугуйн уралдаан;* **нийгэм журмын уралдаан, социалист уралдаан** (хөдөлмөрийн бүтээмж, нийгэм журмын аж ахуйг өрнүүлэн, эв хамт ёсыг тогтоохоод хүргэх хөдөлмөрийн тэргүүний арга).

УРАЛДААХ уралдах.

УРАЛДАХ 1. хоорондоо хурдыг сорих, хурдлахыг турших; *морь уралдах; дугуй уралдах;* 2. шилжсэн өрсөлцөн тэмцэх, хэн түрүүлэхээ үзэх; *уралдан тэмцэх;* 3. шилжсэн булаалцалдан ярих; *хүнтэй битгий уралдан ярьж бай!*

УРАЛДУУЛАХ уралдахын үйлдүүлэх хэв.

УРАЛДУУР мал адгуусны богино хавирганы бураа дээгүүр ургасан бяцхан нарийн мах.

УРАМ I 1. буга, бух зэрэг зарим амьтны отлох цаг үедээ дуудан урхирах дуу; 2. буга адил дуугарах бүрээ; *бугын урам.*

УРАМ II дотроо хөгжих сэтгэл, зориг; **урам зориг** хорш.; **урам орох** (хөгжилтэй

болох): **урам харих** (дотор үхширч зориг алдрах); **урам хугарах** (дургүй, зориггүй болох).

УРАМГҮЙ хөгжөөнгүй, сонирхол дургүй; *урамгүй болох.*

УРАМДАХ 1. буга, бухын хангинан дуугарах; *буга урамдаж байна;* 2. урам дуугаргах.

УРАМДУУЛАХ урамдахын үйлдүүлэх хэв.

УРАМТАЙ хөгжөөнтэй, дур сонирхолтой; *ажил хийхэд урамтай байна.*

УРАМШИЛ урамших үйлийн нэр; 1. дур, сонирхол, шагнал, хөхүүлэл; *тэмцээнд түрүүлсэн хүнд урамшлын юм өгөх хэрэгтэй;* 2. зарим амьтны от; *бухны урамшил.*

УРАМШИХ 1. урам орох, улам урамтай болох; 2. зарим амьтны от урамшил орох.

УРАМШУУЛАХ 1. урамшихын үйлдүүлэх хэв; 2. шагнах, хөхүүлэх; *урамшуулан шагнах.*

УРАН ур 1.

УРАНХАЙ 1. хагархай, урагдсан. урагдаж тасарсан; *уранхай дээл;* 2. ам задгай, яриа.

УРАХ 1. эд бөс мэтийг хүчлэн тасдаж хагалах; *цаас урах; дээлээ урж орхижээ;* 2. хумсаар хүчтэй маажиж шалбалах; 3. юмыг огло татан, хага татан онгорхой, цоорхой, ан гуутай болгох; 4. нохой, чоно зэрэг араатны хүн амьтныг хазаж шархдуулах; *нохой урах; урдаг нохой;* 5. муу үг зааж хүний сэтгэлийг үймүүлэх, хутгах.

УРВААЧ урвагч, урвамтгай, буцамтгай, тогтворгүй; *ноён урваач, нохой шарваач* з үй р.

УРВАГАНАХ 1. уравгар юмны урвага урвага хөдлөх; 2. уйлагнах; **уйлагнах урваганах** х о р ш..

УРВАГАНУУЛАХ урваганахын үйлдүүлэх хэв.

УРВАГАР 1. шарх, нясуу зэргийн дотоод тал ил, хавантай, нойтон, улцгар; 2. уйлсан байдалтай, нус, нулимс гоожсон нь.

УРВАГЧ урваач, урвасан этгээд; *Эх орноосоо урваач.*

УРВАЙЛГАХ урвайхын үйлдүүлэх хэв, урвайхад хүргүүлэх.

УРВАЙХ 1. урвагар болох; *шарх урвайх;* 2. царай муутай байх; *чи юунд урвайгаад байна вэ?*

УРВАЛ урвах үйлийн нэр, химийн урвал хувилахуй ухааны чанараар бодисуудын харилцан нөлөөлөхий нь).

УРВАЛДАХ 1. урвахын үйлдэлдэх хэв; 2. урваганах.

УРВАЛДУУЛАХ урвалдахын үйлдүүлэх хэв.

УРВАЛЗАХ урвагар юмны урвас урвас хөдлөх.

УРВАЛЗУУЛАХ урвалзахын үйлдүүлэх хэв.

УРВАЛТ урвах нь; няцалт, буцалт.

УРВАЛХИЙЛЭХ ийн тийн огт тогтворгүй аашлах.

УРВАМТГАЙ урвахдаа хялбар, няцамтгай, буцамтгай.

УРВАМХАЙ урвадаг зантай, няцамхай, буцамхай.

УРВАХ 1. дотор тал гадагш шамран гарах; *зовхи урвах;* **хошгиног урвах** (хошгиногийн дотор тал гадагш эргэх нэг зүйл өвчин); 2. ш и л ж с э н хөрвөх, эргэх; **урвах хөрвөх** х о р ш.; *газрын хөрс урвах;* 3. өөрийн гэр орноос зайлж өөр айлын болох; *айлд урвасан хүүхэд;* 4. дайсан этгээдийн талд орох, тэрслэх, шудрага биш явах; *урваж ирсэн цэрэг; Эх орноосоо урвах; урван тэрслэгчдийг устган сөнөөгтүн!*

УРВУУЛАХ урвахын үйлдүүлэх хэв, урвахад хүргүүлэх.

УРГАА угаас ургасан юм, ургасан хэвээрээ; *ургаа мод; ургаа чулуу; ураг ургаагаа хүнд, ургаа чулуу газартаа хүнд* з үй р.

УРГАЛТ ургах үйлийн нэр, ургах нь, ургац.

УРГАМАЛ их төлөв хөдөлгөөнгүй бөгөөд газрын хөрс, агаарын амитүй бодисын тэжээл авдаг бие махбодийн нийт нэр; *говийн ургамал; ургамлын аймаг; ургамал модны нахиагар нь жимстэй байхын тэмдэг, унаал атны номхон нь хурдан байхын тэмдэг* з үй р; **эмийн ургамал** (эмнэлэгт хэрэглэдэг өвс, ногоо).

УРГАМАЛГҮЙ мод, өвс ногоо, таримал байхгүй.

УРГАМАЛЗҮЙ ургамлыг судлах ухаан, ботаник; *ургамалзүйн сурах бичиг.*

УРГАМАЛЗҮЙЧ ургамалзүйд мэрэгжсэн хүн.

УРГАХ 1. амьд юм, бие махбодийн амьдран өсөх, томрох; *ногоо ургах; хумс ургах; ургахаар мод байсан юм, ус чийг нь багадсан байна;* 2. шилжсэн зарим юмны мандах, дэгжих; *ургах нарнаар; үүл ургах;* 3. санаа бодол гэнэт төрөх; *сэтгэлд ургах.*

УРГАЦ ургасан байдал; *энэ жилийн тариа ногооны ургац сайн.*

УРГАЦГҮЙ ургац муутай, ургамалгүй.

УРГАЦТАЙ ургамалтай, ургац сайтай.

УРГИХ оргих бургих; *утаа ургих.*

УРГУУЛАХ ургахын үйлдүүлэх хэв, 1. ургахад хүргүүлэх; *улиас ургуулах; ногоо ургуулах;* 2. уршиг тарих; *явдал ургуулах; түвэг ургуулах.*

УРГУУЛУУШТАЙ ургуулбал зохистой.

УРГУУШТАЙ ургамаар байдалтай.

УРД 1. өмнө; *урд зүгийн дулаан орон; урд хөл; урд этгээд;* 2. өвөр, нүүр тал; *урд урдаасаа харж суух;* 3. түрүүнд; *би урдаар явах ёстой; журмаараа бол чи урдаар явах ёстой.*

УРДАХЬ урд бий, өмнө нь орших, өмнөх.

УРДДАХ урагшдах.

УРДДУУЛАХ урддахын үйлдүүлэх хэв, урагшдуулах.

УРДУУР урд талаар, өмнө талаар; *урдуур сууж байгаа хүмүүс; бидний урдуур нэг хэсэг зээр давхин өнгөрөв.*

УРДУУРХАН баахан урдуур, арай урдуур, нилээд урдуур.

УРДУУРХИ урдуур бий, урдуур орших.

УРДУУРХИН жаахан урдуурхи, арай урдуурхи, баахан урдуурхи.

УРДХАН арай урд, баахан урд.

УРЖДАР өцөгдрийн урд өдөр, уржигдар; *бид урждар ирсэн; урждарын цаад өдөр.*

УРЖИГДАР урждар.

УРЖИЙН: уржийн цаад өдөр урждарын цаад өдөр.

УРЖНАН өнгөрсөн жилийн урд жил; *уржнан би энд байв; уржнан жил; уржнаны байсан өвөлжөөнд манайх буув.*

УРИА 1. урих тэмдэг, дохио; **уриа татах** (бүрээ үлээж урих); **уриа цохих** (юм дэлдэж урих); **уриа тэмдэг** (а. жүжгийн дуудах, мэдэгдэх тэмдэг; б. худалдааны газрын үүдэнд өлгөсөн худалдах юмны тэмдэг); 2. нийтэд зарлан уриалж тунхаглах бичиг, уриалга: *ард иргэдэд гаргасан уриа; Октябрийн баярын уриа;* 3. хур буухын өмнөх чийгтэй агаар бүхий найрт салхи; *уриа салхи.*

УРИАДАХ уриа татах, уриа дуугаргах.

УРИАДУУЛАХ уриадахын үйлдүүлэх хэв.

УРИАЛАГ дуулгавар сайтай, ааш зан сайтай, эелдэг, хөнгөн, уриалган.

УРИАЛАГДАХ уриалахын үйлдэгдэх хэв.

УРИАЛАГХАН арай уриалаг, баахан уриалаг, нилээд уриалаг; *уриалагхан зантай хүн; уриалагхан хөдлөх.*

УРИАЛАЛ уриалах үйлийн нэр.

УРИАЛАХ 1. урих, уриадах; 2. зарлан дуудах; зарлан дуурилгах, дуудан дагалдуулах; *сонин захигтүн гэж уриалав; ажлын төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө биелүүлье гэж уриалав.*

УРИАЛГА I олон түмнийг аливаа үйл ажилд уриалан дуудаж бий юм, бичиг, тунхаг, уриа; *уриалга гаргах.*

УРИАЛГА II уриалаг.

УРИАЛГА III боролзгоно.

УРИАЛГАН уриалаг, уриалагхан.

УРИАЛУУЛАХ уриалахын үйлдүүлэх хэв.

УРИВЧЛАХ урьдчилах.

УРИГНАХ урилах.

УРИЛАХ хилэгнэх, уурлах.

УРИЛГА урих мэдээ, хэл; *урилга айлтгая!* **урилгын хуудас** (урих учрыг илтгэсэн бичиг); **урилга илгээх** (урихаар хүн бичиг явуулах).

УРИН I цаг улирлын дулаан; *урин дулаан цаг; урин дулаан болох.*

УРИН II уур хилэн; *урин мунхаг; урин тачаангуй.*

УРИХ I ирүүлэхээр хүндэтгэн дуудах, залах; *таныг бид урьж байна;* **бүжигт урих** (бүжиг хийнэ үү гэж гуйх); **урих шошго** (урих хүний тэмдэг болгох шошго).

УРИХ: **урих салхи** өмнө зүгээс халуун салхи салхилах; *урдаасаа урьж байна, бороо орох нь бололтой.*

УРЛАГ I 1. үнэн байдлыг уран сайхан дүрээр гаргах бүтээл; *урлагийн хэрэг эрхлэх хороо; соёл урлагийн ажилтан нар;* 2. уран, гоёмсог; **урлаг судлал** (голчлон дүрслэх урлагийг судлах ухаан; *урлаг судлалын ухааны дэд эрдэмтэн*); **урлаг судлалч** (урлаг судлалд мэрэгжсэн хүн).

УРЛАГ II у р г а м а л гичгэний төрлийн нэг зүйл ургамал; **урлаг бялзуухай** а м ь т а н (уран шувууны төрлийн бялзуухай).

УРЛАЛ урлах үйлийн нэр; *урлал сайтай; хийц урлал.*

УРЛАХ 1. уран гоёмсог зүйл үйлдэх; *урлаж байгаа угалз нь сайхан байна; урлах газар;* 2. ш и л ж с э н уран үг хэлэх.

УРЛУУ уралгуу.

УРЛУУЛАХ урлахын үйлдүүлэх хэв.

УРМАС урам; *урмас хугалах.*

УРСАХ 1. ямар нэгэн чигт асаран, цутган хөдлөх; *Туул гол баруун тийшээ урсана.* 2. усанд хөвөх; *усан дотор мод урсч явна; хөл алдран урсах;* 3. ихэд гоожих; *цус урсах;* 4. хайлах, уусах; *халуунд урсч хоцроход хүрлээ;* 5. цахилгаан токийн хөдлөх, гүйх; *цахилгаан урсах.*

УРСГАЛ урсах үйлийн нэр; 1. ямар нэгэн чигт урсан хөдлөх байдал; *ширүүн урсгалтай гол; далайн халуун урсгал;* 2. урсдаг, урсч байгаа нь; *урсгал устай газар;* 3. юмны ямар нэгэн чигт хөдлөх; *салхины урсгал;* 4. цахилгаан гүйдэл; *цахилгааны урсгал;* 5. ш и л ж с э н шаардлагагүй аяндаа, зөндөө болох байдал; *хариуцлага суларч урсгалын чанартай болов.*

УРСГАХ урсахад хүргүүлэх, урсуулах; *сал урсгах; цус урсгасан дайн*

УРСГУУЛАХ урсгахын үйлдүүлэх хэв.

УРСУУЛАХ урсахын үйлдүүлэх хэв.

УРТ охор, богино гэдэгтэй эсэргүүцэлдсэн үг, 1. зураас шугам, хавтгай биет юмны захын хоёр чиг бие биенээс хамгийн хол байх чигийн дагуу хэмжээ; *уртын хэмжээ; урт нь арван метр; хушуу урт бол хүзүү ороохо, хормой урт бол хөл ороохо* з ү й р; 2. уртын хэмжээ үлэмж; *урт мод;* **урт хэлт** ш и л ж с э н (үг яриа ихтэй, ховч); **урт хушуут** (ховч, хов хүргэгч); **урт чихт** (юм их сонсдог); **уртын харайлт** (холын зайд харайх харайлт); **урт хорхой** ц э э р л э с э н (могой); **урт сүүлт цагаан хуй шаазгай** а м ь т а н (сүүл хуй шаазгайн сүүлээс урт нэгэн зүйл шаазгай); 3. ш и л ж с э н удаан; **урт удаан** х о р ш.; *урт насалж удаан жаргах болтугай!* **урт намар** (удаан намар); **урт эгшиг** (сунжруулан удаан хэлэх эгшиг); **уртын дуу** (урт удаан, аялгуутай дуу); 4. ш и л ж с э н хол, алс; **уртын жин** (холын жин); **урт сандал** (хэдэн хүн зэрэгцэн суух сандал); **урт хүч** х у у ч и р с а н (ацаг авч нэг жилээс доошгүй удаан хугацаагаар ажил гүйцэтгэх хүн).

УРТААШ урт тийш; *уртааш нь хэмжих; уртааш дөрвөн метрийн банз.*

УРТАВТАР арай урт, нилээд урт; *уртавтар нь над хэрэгтэй.*

УРТАЙ I 1. уран, дүйтэй; *гартаа уртай;* 2. гоёмсог нарийн хийцтэй.

УРТАЙ II ур, цулцантай; *хүзүүндээ уртай хүн.*

УРТАСГАХ уртсахын үйлдүүлэх хэв, урт болгох; *бага зэрэг уртасгах ёстой.*

УРТАСГУУЛАХ уртасгахын үйлдүүлэх хэв.

УРТАТГАЛ уртатгах үйлийн нэр; **уртатгалын тэмдэг** (урт эгшгийг тэмдэглэх тэмдэг).

УРТАТГАХ урттахын үйлдүүлэх хэв.

УРТАТГУУЛАХ уртатгахын үйлдүүлэх хэв.

УРТАЧЛАХ 1. авиа, дууг сунгаж удаан болгож дуудах, аялах; 2. уртаас нь шилж авах; *бургасны уртаас нь уртчилж авав.*

УРТАЧЛУУЛАХ уртачлахын үйлдүүлэх хэв.

УРТДАХ хэтэрхий урт болох; *уртадсан ханцуйтай дээл.*

УРТДУУЛАХ уртдахын үйлдүүлэх хэв.

УРТЛАГ урт байдалтай, уртхан хэлбэртэй; *уртлаг тархи.*

УРТРАГ газар зүй тодорхой меридианаас градусаар илэрхийлэгдсэн зай.

УРТСАХ улам урт болох.

УРТТАХ улам урт болох.

УРТХАН баахан урт, нилээд урт; *арай уртхан шигий нь аль.*

УРТШИГ уртавтар, арай урт; *уртшиг юм байна уу?*

УРУУ 1. дээрээс доошоо; *урууга буух; үүл уруу буух;* **уруу газар** (тонгоргон, улам доошоо болох газар); 2. шилжсэн дорой, үхээнц, ядуу; *уруу царай гаргах; уруу царайлах*; 3. ямар нэгэн юмны чигт, зүгт; *ус руу очих; хүн рүү харах;* ☆ **уруу татах** (муу замд оруулах); уруу суух (чацга алдах).

УРУУДАМТГАЙ урууддаг.

УРУУДАХ 1. доошоо явах, эхэн талаас адаг тийш явах; *үүл урууда; гол урууда; салхи урууда явах; хонь шуурганд урууда;* **урууда хос эгшиг** (зэрэгцэж орсон хоёр өөр төрлийн эгшгийн нэгдүгээр нь үе бүтээх эгшиг); 2. ажил үйлс бүтэхгүй, хоосрох, доошлох, муу замд орох; *урууда хад буруудах зүйр; урууда яваа хүн.*

УРУУДУУЛАХ урууда хын үйлдүүлэх хэв.

УРУУЛ хүн амьтны амны хамхих хэсэг; *дээд урууд; доод урууд; урууда а хазах;* **урууда а унжуулах** (гомдох царай гаргах): **урууда ын эгшиг, урууда ын гийгүүлэгч** (өгүүлэхэд урууд оролцох эгшиг, гийгүүлэгч).

УРУУЛДАХ урууда ас нь барих, торгох, амдах, цоровдох.

УРХАВЧ урхи.

УРХАГ I 1. шалтгаан, уг учир; **уг урхаг** хорш.; *урхаг шалтгаан; урхаг нь юундаа байна вэ?* 2. өвчний шалтгаан, уг; *өвчний урхаг.*

УРХАГ II хэтэрхий хашин, хойрго зан байдалтай.

УРХАГЛАХ 1. урхаг үлдэх; 2. урхаг зан ааль гаргах.

УРХАН нилээд уран, баахан уран, арай уран; *урхан үгээр намайг мэхлэх нь үү.*

УРХИ 1. амьтныг оосорлон барих, чангарах гогцоо бүхий оосор; *оготнод урхи тавих;* 2. цалам; **урхи цалам** хорш.; 3. шилжсэн мэх, ов, муу арга; *урхинд орох.*

УРХИДАГДАХ урхидахын үйлдэгдэх хэв.

УРХИДАХ урхиар барих; *хүүхэд оготно урхидаж барьжээ.*

УРХИДУУЛАХ 1. урхидахын үйлдүүлэх хэв; 2. урхидагдах.

УРХИЛАГДАХ урхилахын үйлдэгдэх хэв.

УРХИЛАХ урхидах.

УРХИЛУУЛАХ 1. урхилахын үйлдүүлэх хэв; 2. урхилагдах.

УРХИРАХ архирах, хорхирох.

УРХИЧ урхи хэрэглэхдээ чадамгай.

УРЦ овоохой; *өвсөн урц; холтсон урц; урц гэр;*

УРЧЛАХ 1. уран гоёмсог хийх; 2. шилжсэн урьхнаар хэлэх, чимэглэн ярих.

УРЧУУД олон уран; *урчуудын артель.*

УРЧУУЛ урчууд.

УРШИГ чирэгдэл, яршиг; *уршиг удах; чийний уршгаас болов; эс гүйцэтгэсний уршгаар.*

УРШИГЛАХ уршиг удах, чирэгдэл гаргах.

УРЬ (УРИН) 1. салхи; **урь унах, урь орох** (хавар болж дулаарах, хаварших); **урь идэх** (салхинд өврөх); 2. дулаан; *урин цаг; урин дулаан болгох;* 3. шилжсэн зөөлөн; **урин зөөлөн** хорш.; *урин зөөлөн сэтгэлтэй.*

УРЬД 1. өнгөрсөн үед, тэргүүнд, эрт; *эрт урьд нэгэн цагт ...; урьд хожид үзэгдээгүй зүйл; урьд нь байсан хүн; урьдын нэгэн явдлыг хэлэв; урьд урьдын хүмүүс ингэж хийсээр ирэв; урьдын хийсэн үйлийн үр;* 2. өмнө, түрүүн; *чи урьдаар ир;* 3. эрт, тэргүүн; *урьдаас болгоомжлох; урьдаас мэдэж байв; урьдаас хамгаалах; урьдаас бэлтгэх; урьд урьдаас илүү их өвс авав.*

УРЬДАЛ урьд, тэргүүнд оруулбал зохих зүйл; *урьдал болгох чухал зүйл.*

УРЬДАХЬ өмнөх, урьд нь байсан; *урьдахь явдлаа санав; урьдах жил нь цас ихтэй байжээ.*

УРЬДХАН арай урьд, баахан урьд.

УРЬДЧИЛАХ 1. урьдаар гүйцэтгэх, түрүүлж гүйцэтгэх; *урьдчилан сэргийлэх; урьдчилан сануулах; урьдчилсан арга хэмжээ;* 2. урьдаар авах, түрүүлж авах; 3. түр зээлдэх, урьдчилга авах; *мөнгө урьдчилах.*

УРЬДЧИЛГАА 1. аливаа ажил үйл хийхийг хэлэлцэн тохирч хөлсний зохих хувийг урьдчилан авах; 2. мөнгийг дараа тооцоо хийхээр өгөх, авах; *урьдчилгаа авах; урьдчилгаа өгөх.*

УРЬДЧИЛУУЛАХ урьдчилахын үйлдүүлэх хэв; *таван зуун төгрөг урьдчилуулахыг хүсье.*

УРЬСАХ урьтах II.

УРЬТАХ I түрүүнд нь болох, урьдаар болох, тэргүүлэх, өрсөх; *би урьтаж хэлэв.*

УРЬТАХ II урь орох, урин болох, урьших.

УРЬТУУЛАХ урьтахын үйлдүүлэх хэв.

УРЬХАН 1. тааламжтай, дулаан, зөөлөн; *урьхан хонгор салхинд нь. уулын мод найгана* (дуу); 2. элдэг, нийлэмжтэй, зан ааш сайтай; *урьхан голшиг чамдаа, удах тусмаа янагшина* (дуу).

УРЬЧЛАХ урьдчилах.

УРЬЧЛУУЛАХ урьчлахын үйлдүүлэх хэв.

УРЬШИХ 1. урин дулаан болох; 2. урьидэх.

УС 1. устөрөгч хүчилтөрөгч хоёрын химийн цэвэр нийлэл болох өнгөгүй, тунгалаг, шингэн зүйл; 2. гол, нуур, тэнгэс зэрэг усан гадаргуу; *усан дээр очих; ус гатлах; ус үзээгүй гутал тайлах, уул үзээгүй хормой шуух* зүйр; **ус авах** (а. үерт автах, ус хальж эздэх; *манайхыг ус авчих шахав;* б. хэрэглэх усаа тээж авчрах; *гурван хувин ус авав; тэмээгээр ус авлаа;* в. шээс шинжлэхээр авч бэлдэх; *өглөөний өлөн усаа авах хэрэгтэй);* **ус гарах** (а. газраас ус нэвчих; б. ус гатлах); **ус гатлах** (гол мөрөн, горхи нуур мэтийн усны энэ тээгээс тэртээ нь гарах: б. ус туулах); **ус туулах** (а. усанд хөлөөр явах; туучих; б. гэрт ус үер орж ирэх); **ус зэтгэх** (ус гатлах); **ус нэвтрэх** (аливаа юмыг ус туулан гарах, нэвчих); **уух ус** (уухад тохирох ус); **ус татах** (а. тариалан зэрэгт оруулахаар өөр газраас ус урсгаж ирэх; б. ус татрах); **ус татрах** (үерлэсэн ус улмаар бага болон одох); **ус үерлэх** (үер болох); **ус хадаалах** (ус гүйцэд хөлдөх); **ус оргилох** (а. ус газраас дээш оволзон гарах; б. ус тогоо саванд маш ихэд буцлах); **ус бялхах** (сав хэмжээнд ус ихэд дүүрэх); **ус бялдах** (ус сав хэмжээнээс хэтэрч асгарах, гадагш гарч тунаж урсах); **ус шүүрэх** (а. газраас ус дааварлан гарах; б. юм хүмнээс ус гарах; в. яр шарх мэтээс ус цуврах); **ус даацлах** (газраас ус гарах шахамдан чийг дааварлан гарах); **ус зайртах** (усны дээгүүр өчүүхэн нимгэн мөс хөлдөх); **ус гэсэх** (хавар цаг урин унаж гол горхины мөс хайлах, тавигдах); **ус хөлдөх** (усны мөс болох); **ус хөрөөлөх** (хүйтэн орох цагт голын захаар эрэг мэт ирмэг гарч хөлдөх); **усанд хөвөх** (а. юм усны дээгүүр явах; б. живсэн юм усны дээгүүр дэгдэн гарах); **усанд живэх, чивэх** (усанд хөвж чадахгүй доошоо орох); **усанд сэлэх** (сэлүүрээр буюу гар хөлөөр ус сэлж явах); **усан хуй** (ус багана мэт босч эргэлдэн явах хүчтэй хуй); **усны ирэлж** (салхинаас усанд гарсан хунираа); **усны боргио** (усны их л чимээлэн урсах газар); **усны гарам** (ус гатлах зам, гарц); **усны олом** (ус гатлаж болом нимгэн газар); **усны сан** (а. усан хадгаламж, цөөрөм; б. хуучирсан далай); **усны эх** (усны үүсгэлийн газар); **усны хариг** (усны маш нимгэн газар); **усны хүрхрээ** (усны өндрөөс буух газар); **усны уур** (ус халснаас гарах уур); **усны цорго** (а. саравчны усыг хамтатгах хэрэгсэл; б. ус гоожуулах цорго); **усны эргүүлэг, усны уйл** (усны эргэлдэн бий гүн газар); **усны сав** (ус агуулах сав); **усны сав газар** (нуур, мөрөн, түүнд цутган орох голуудад хуран юүлэх усны эзлэн бүхий газар); **усны цалгиа** (ус хөдөлж савнаасаа гадагш халгих, урсах); **усны дусал** (нэжгээд нэжгээдээр өчүүхэн дусах ус); **усны долгио** (далай, их мөрөн, нуурын ус салхинд хөдөлж дараа дараагаар гүйх давлага); **усны таргил** (ус гүехэн бөгөөд урсгал түргэн газар); **усны дарвилзуур** (усны харгиа); **усны замаг** (усны дотор бүтэж боловсрох хөвөн мэт бөгөөд өнгө ногоон юм); **усны харгиа** (чулуутай буюу өөтэй газар урссан нимгэн усны ирвэгнэх байдал); **усны харз** (өвлийн хүйтэн цагт хөлдөхгүй өрхлөн гарсан ус); **усны урсгал** (а. газрын уруу тийш усны хальж гүйх хөдөлгөө; б. үер, хурын усны урсах мөр, зам газар); **усны эрэг** (мөрөн гол, далайн усны зах ирмэг газар); **усны ар** (ус салхи буюу өөр юмны хөдөлгөөнд гарсан жижиг долгио); **хөлгүй ус** (маш гүн бөгөөд хүн амьтны хөл хүрч гишгэн

туулж чадахгүй газар); **усан доогуур** (усан дотуур, шунгадаг, усан дор); **усанд автах** (ус хальж эзлэх); **усанд авахуулах** (ус эзлэж, яах аргагүй болох); **усанд орох** (угаах болон эмчлэх сувилахын тулд усан дотор орох; *халуун усанд орох; голын усанд орох; аршаан усанд орох);* **усан оргилуур** (шахуургын хүчээр дээш оргилон олгойдох ус); **усан хөөрөг** (галын аюулыг сөнөөх хэрэгсэл); **усан хулгана болох** (ихэд хөлрөх); **усан тээрэм** (усны урсгалын хүчээр ажиллах тээрэм); **усны аюул** (үер, усны гамшиг); **усан зам** (усанд явах, аялах зам); **усан замын цэрэг, усан цэрэг** (тэнгэсийн цэрэг); **усанд сайн** (а. усанд явахдаа сайн; б. усанд норвол сайн; в. ус үл нэвтрэх сайн чанартай); **усанд муу** (а. усанд явахдаа муу; б. усанд норвол муу; в. ус нэвтрэх муу чанартай); **усан будгийн зураг** (усан будгаар будсан зураг); **усан будаг** (усаар шингэлж будах будаг); **усан эм** (шингэн эм); **ус төрөгч** (амт үнэргүй маш хөнгөн хий махбод, хүчилтөрөгчтэй нийлбэл ус болно); **усан уусгамал** (хатууг усанд уусгасан уусгамал); **мөнгөн ус** (мөнгөлөг цагаан өнгөтэй, хүнд чанартай бөгөөд шингэн махбод); **ус задлах** (усаар задлах зарим нэгэн бодис, гидролиз); **усан хаван** (шингэн цус зэрэг хэмжээнээс хэт хуралдаж цэлхрэн хавагнах өвчин; *усан хаван гүйх*); **усан шил** (а. маш тунгалаг шил: б. усан болор); **усан болор** (шил адил тунгалаг, гонзгойвтор, талсттай чулуу); **ус уух хувь** амьд явах хувь зохиол); **усан тэнэг** (юу ч мэдэхгүй, мангуу тэнэг); **усны шувуу** (устай газар орших галуу, нугас зэрэг шувуудын нийтийн нэр); **усан булга** амьтан (өмхий хүрнийн төрлийн араатан амьтан, бие бага, сортой хар хүрэн үстэй, ноолуур их, тэжээж арьсыг авна); **усны шаазгай** амьтан (хушуу урт бөгөөд хар, толгой цагаан, сүүл охор, шилбэ өндөр, элс хойг газар сууж загас идэг шувуу); **усан тас** амьтан (халуун оронд байдаг шувуу, хушуу том бөгөөд хоолойд нь хөөе бий, жижиг амьтан иднэ, сүүлийг чимэг болгон хэрэглэдэг тул үнэ ихтэй); **усан бүднэ** амьтан (бие бүднэтэй адил боловч баахан нарийн урт хөлтэй, хөлийн өмнөх гурван хуруу урт, эрхий богино нэг зүйл бялзуухай); **усны барс** (эдэн загас); **усны нохой** (халиуны өөр нэр): **усны үхэр** амьтан (бие том, эвэр урт, ус тачир, усанд хэвтэх дуртай, хүч маш их нэг зүйл үхэр, эврий нь нум хийхэд хэрэглэнэ); **усны ирвэс** амьтан (умард мөсөн далайн хавь газар байдаг, хөхөөр бойжих амьтан, байдал болхи, хүнд нүсэр, ил чих байхгүй, шүд араатан мэт, үс хатуу, ноолуур зөөлөн, хөлийн хуруу холболдсон нь усанд хөвж сэлж чадна, арьс өөх нь их үнэд хүрнэ); **усан ууль** амьтан (уулийн адил нэг зүйл цахлай); **усан аалз** амьтан (хөл өндөр, усны дээгүүр явдаг аалз); **усан хулгана** амьтан (гол нуурын хавь газраар байдаг мэрэгч амьтан, сүүл урт, өнгө бор саарал, зурамны хир биетэй, өвсний үндэс, зэгс иднэ); **усан гахай** амьтан (мэрэгчийн багт ордог нэг зүйл оготно); **усан хоног** ургамал (монгол амуутай адилавтар, өөр нэг зүйл тариа); **усан үзэм** ургамал (а. халуун дулаан газар ургадаг, нэг зүйл жимсгэнэ, жимсгэнийн өнгө шаравтар, ногоон, хүрэн улаан, амт амтайхан, шүүс их, бас дарс хийнэ; б. мөн жимсгэнийн мод; *усан үзэм тарих; усан үзмийн мод*); **усан чацаргана** ургамал (навч хатан чацарганын адил, цэцгийн өнгө улаан шар хүрэн гурван зүйл байдаг нэг зүйл цэцэг); **усны мөнх мод** ургамал (янз балуу модтой адил болоод навч нарийн, усны ойр ургадаг нэг зүйл мод); **усан сонгино** ургамал (дотор хөндий, сонгинотой адил болоод өндөрхөн, үзүүрт түрүү бий, усанд ургана); **усан цэс** ургамал (янз бөөрөнхий, түүхий идэж болдог нэг зүйл ногоо, цагаан хар хоёр зүйл бий); **усан шимэлдэг** ургамал (иш бор мажстай адил, цэцгийг цацаг цэцэг гэж нэрлэдэг нэг зүйл ургамал). ᠤᠰᠤᠨ

УСАВХИ амт чанар муутай архи, сувс ч гэдэг. ᠤᠰᠠᠪᠬᠢ

УСАРХАГ ус ихтэй, усархуу; *намагтай усархаг газар.* ᠤᠰᠠᠷᠬᠠᠭ

УСАРХУУ 1. усархаг; 2. ус мэт. ᠤᠰᠠᠷᠬᠤ

УСГАЛ амарлингүй, дөлгөөн; **усгал зөөлөн, усгал номхон** хорш.. ᠤᠰᠭᠠᠯ

УСГҮЙ ус байхгүй, усны хувь маш бага; *усгүй архи; усгүй цөл нутаг.* ᠤᠰᠭᠦᠢ

УСДАХ хэтэрхий ус болох. ᠤᠰᠳᠠᠬᠤ

УСЖИХ устай болох. ᠤᠰᠵᠢᠬᠤ

УСЖУУЛАЛТ усжуулах үйлийн нэр. ᠤᠰᠵᠢᠭᠤᠯᠠᠯᠲ

УСЖУУЛАХ усжихын үйлдүүлэх хэв. ᠤᠰᠵᠢᠭᠤᠯᠬᠤ

УСЛАГ ус ихтэй. ᠤᠰᠯᠠᠭ

УСЛАГДАХ услахын үйлдэгдэх хэв. ᠤᠰᠯᠠᠭᠳᠠᠬᠤ

УСЛАЛТ усалсан байдал; *энэ модны услалт муухан байна, дахиж услах хэрэгтэй.* ᠤᠰᠯᠠᠯᠲ

УСЛАХ 1. ус асгаж урсган чийглүүлэх; *эсгий услах; тариалангийн газар услах; услах суваг;* 2. малд ус уулгах; *хонио худгаас усалж байв.* ᠤᠰᠠᠯᠬᠤ • ᠤᠰᠠᠯᠬᠤ

УСЛУУЛАХ 1. услахын үйлдүүлэх хэв; 2. услагдах. ᠤᠰᠠᠯᠭᠤᠤᠯᠬᠤ

УСЛУУР усалдаг хэрэгсэл. ᠤᠰᠠᠯᠭᠤᠤᠷ

УСТ ус бий; **уст хяаг** у р г а м а л (усанд ургадаг ургамал, өндөр нь 10—25 см. хоёроос гурав салаалж цэцэг ургана, дугуй навчны гадна талаар улаан сормуус буй, сормуус нь сочромтгой бөгөөд ялаа, шавьж суувал цавуулаг шүүс гаргаж наалдуулан барина). ᠤᠰᠤᠲᠤ

УСТАЙ ус бүхий; *устай газар.* ᠤᠰᠲᠠᠢ

УСТАХ I 1. үгүй болох, арилах; *уст, тонил! бичиг үсэг үл мэдэх явдал устжээ;* 2. сөнөх, мөхөх; *феодалын анги устжээ.* ᠤᠰᠲᠠᠬᠤ

УСТАХ II 1. улам устай болох, ус нь үлэмждэх; 2. цас мөс гэсч ус болох; 3. яр, нясуу мэтэд ус, шингэн зүйл тогтох, **уушиг устах** (өвчнөөр цээжний хөндийд шингэн зүйл бий болох); 4. ш и л ж с э н эхийн умай дотор анх үр үүдэж тогтох. ᠤᠰᠠᠬᠤ

УСТГАГДАХ устгахын үйлдэгдэх хэв. ᠤᠰᠲᠭᠠᠭᠳᠠᠬᠤ

УСТГАГЧ устгадаг юм. ᠤᠰᠲᠭᠠᠭᠴᠢ

УСТГАЛ устгах үйлийн нэр. ᠤᠰᠲᠭᠠᠯ

УСТГАХ устахын үйлдүүлэх хэв. ᠤᠰᠲᠭᠠᠭᠤᠯᠬᠤ

УСТГУУЛАХ 1. устгахын үйлдүүлэх хэв; 2. устгагдах. ᠤᠰᠲᠭᠠᠭᠤᠤᠯᠬᠤ

УСТӨРӨГЧ ус төрөгч. ᠤᠰᠲᠥᠷᠥᠭᠴᠢ

УСТУУЛАХ устах II-ын үйлдүүлэх хэв. ᠤᠰᠲᠤᠤᠯᠬᠤ

УСЧ (ИН) 1. усанд чадамгай хүн; *усчин, аянчдыг онгоцоор гаргаж байв;* 2. ус зөөгч; *морин тэрэгтэй усчин.* ᠤᠰᠴᠢ

УСЧЛАХ усанд чадамгай явах, сэлэх, самрах; *усчлан гатлах.* ᠤᠰᠴᠢᠯᠠᠬᠤ

УТАА юм шатахад гарах нүүрсний нарийн ширхэг бүхий хөөрөх зүйл; *галын утаа; тамхины утаа;* **утаа тавих** (ямар нэг зорилгоор их утаа гаргах); **утаа баагих** (утаа оргилон гарах); **утаа суунаглах** (утаа тунарч баахан гарах); **утаа хоргодох** (утаа авд гарахгүй болох); **утаа орох** (утаа шингэх); **утаанд согтох** (нүүрстөрөгчийг гүйцэд шатаагүйгээс үүсэх хорт хийд согтох); **утаан хөшиг** (утаа тавьж халхлах арга). ᠤᠲᠠᠭᠠ

УТААГҮЙ утаа гардаггүй, утаа байхгүй; *утаагүй дарь.* ᠤᠲᠠᠭᠠᠭᠦᠢ

УТААДАХ юмыг утаа болгож бохирлох, утаа шингээх; *гэрээ утаадаж орхив; утаадсан хиам.* ᠤᠲᠠᠭᠠᠳᠠᠬᠤ

УТААДУУЛАХ утаадахын үйлдүүлэх хэв. ᠤᠲᠠᠭᠠᠳᠠᠭᠤᠤᠯᠬᠤ

УТААРЬ загас, мах зэргийг утах газар. ᠤᠲᠠᠭᠠᠷ

УТААТ утаа бүхий; **утаат од** (сүүлт од); **утаат сум** (харвахад утаа гарах нэгэн зүйл сум); **утаат хотон** (тоосго шороогоор өндөр цогцлон хийсэн газар, тэмдэгт гал утаа ноцооно); **утаат болор** (утаа тунасан мэт өнгөтэй нэг зүйл болор); **утаат мана** (утаа мэт бараан өнгө холилдсон нэг зүйл мана). ᠤᠲᠠᠭᠠᠲᠤ

УТААТАЙ утаа бүхий; *утаатай дарь;* **утаатай цуцал** (дутуу шатсан модны үлдэгдэл). ᠤᠲᠠᠭᠠᠲᠠᠢ ᠴᠤᠴᠠᠯ

УТААДАХ юманд утаа сууж авд гарахгүй болох. ᠤᠲᠠᠭᠠᠳᠠᠬᠤ

УТАГДАХ утахын үйлдэгдэх хэв. ᠤᠲᠠᠭᠳᠠᠬᠤ

УТАС (УТСАН) 1. ёнхор, хөвөн зэргийг нарийн болгож цувж нийтгэсэн нь; *юм оёх утас; хөгжмийн утас;* **утас өлгөлцөх** (нэг зүйл тоглоом); **утас ээрэх** (утсыг ээрүүл зэрэг хэрэгсэлд хийж нийтгэх); **утас нийтгэх** (утсыг томох); 2. төмөрлөгийн зүйлийг нарийн цувсан нь; *төмөр утас; зэс утас; чийдэнгийн утас;* 3. телефон, дууг цахилгааны хүчээр төмөр утсаар дамжуулан алсад хүргэх хэрэгсэл; *утсаар ярих;* ☆ **цахилгаан утас** (мэдээг цахилгааны хүчээр төмөр утсаар дамжуулан алсад хүргэх хэрэгсэл); **утас тавих** (а. цахилгаан утасны шугам тавих; б. телефон утсан аппаратыг залгах); **баярын утас** (баяр хүргэж ирүүлсэн буюу явуулсан цахилгаан мэдээ); **утас цохих** х у у ч и р с а н (цахилгаан мэдээ явуулах); **утас явуулах** (цахилгаан мэдээ илгээх); **утас татах** (утас тэлж тогтоох); **утасны хороо** (цахилгаан мэдээний газар); **утсан хорхой** а м ь т а н (хавтгай хорхойн анги, их төлөв мах идэх сээрт амьтны гэдсэнд оршино, гэдэсгүй, идшийг хөвчин биед сорно, биедээ маш олон хэрчээстэй нэг зүйл хорхой). ᠤᠲᠠᠰ

УТАСГҮЙ утас байхгүй; *юм оёх утасгүй; телефон утасгүй айл байна.* ᠤᠲᠠᠰᠭᠦᠢ ᠤᠲᠠᠰᠤᠨ

УТАСДАХ 1. утсан хэмжүүрээр заах; 2. утсаар ярих; *гэрээсээ утасдав.* ᠤᠲᠠᠰᠳᠠᠬᠤ

УТАСДУУЛАХ утасдахын үйлдүүлэх хэв. ᠤᠲᠠᠰᠳᠠᠭᠤᠤᠯᠬᠤ

УТАСЛАХ 1. утасдах, утсан хэмжээ тавих; 2. утас тавьж чимэглэх; 3. хөгжимд утас чавхдас хийх. ᠤᠲᠠᠰᠯᠠᠬᠤ

УТАСЛУУЛАХ угаслахын үйлдүүлэх хэв.

УТАХ 1. утааг амьсгалаар соруулах; 2. зарим амьтныг агнахаар нүхэнд нь утаа оруулах; *тарвага утах;* 3. утаа шингээх; *арьс шир утах; утсан хиам; утсан мах;* 4. шилжсэн утаа баагиулах; *тамхираа утах.*

УТГА агуулга, гол санаа; **утга агуулга, утга учир, утга санаа** хорш.; **утга чанар** (гол агуулга); **гүн утга** (гүн агуулга); **утга төгөлдөр** (утга төгс); **далд утга** (а. ил биш агуулга; б. ёгт); **битүү утга** (далд агуулга); **ёгт утга** (ёжилсон агуулга); **утга зохиол** (уран зохиол); утга соёл (оюуны боловсрол); **утга уянга** (яруу найргийн нэг зүйл; *утга уянгын шүлэг*).

УТГАГҮЙ агуулга байхгүй, утга байхгүй; *утга учиргүй.*

УТГАХ ямар нэгэн сав юмаар шингэн буюу хэмхдэг үйрмэг юмнаас авах; *шанагаар ус утгах; хүрзээр шороо утгах.*

УТГАЧ юмны утга учрыг ухах, туулахад сайн хүн.

УТГАЧЛАХ бичиг зохиолын утгын дагуу үйлдэх; **утгачлан орчуулах** (үг нэгбүрийг махчлан дагахгүй, гол утгыг авч орчуулах).

УТГУУЛАХ утгахын үйлдүүлэх хэв.

УТГУУР утгах хэрэгсэл; *үгалзын эврээр утгуур хийгээд ...* (ерөөл).

УТЛАГА 1. юмыг утахад шатаах зүйл; 2. ялаа зайлуулах май.

УТОПИ үл гүйцэлдэх үзэл.

УТУУЛАХ 1. утахын үйлдүүлэх хэв; 2. утагдах.

УТУУР утах хэрэгсэл; *арьсны утуур.*

УУ 1. асуух үг, эр үгийн дараа орно; *сайн байна уу? таны хонь хотолсон уу? та эзэжгээ эргэж очсон уу?* 2. хүсэх үг, эр үгийн дараа орно; *дурьдсан зүйлийг олгоно уу; та захиалсан номоо авна уу.*

УУГАА аугаа.

УУГАН 1. хамгийн ах, түрүүлж төрсөн нь; *ууган хүү; ууган хурга;* 2. ахмад; *намын уугаа гишүүн.*

УУГИУЛАХ уугихын үйлдүүлэх хэв.

УУГИХ утаа, уурын багсран оргилох; *утаа уугих; хомоол уугих; арц уугих.*

УУГУУШТАЙ уучихмаар аятай; *уугуушгай цай; уугуушгай айраг.*

УУДАМ I 1. уужим, тавиу, үлэмж зайтай; *уудам эх орны дундуур, Орхон Туулын билчээрээр, ган зам зурайн гялалзаад, галт тэрэг хурдлан явна* (дуу); 2. тайван, амгалан, өршөөнгүй, энэрэлт; *уудам хүн; уудам зан; уудам сэтгэлтэй.*

УУДАМ II хуучирсан тусам хадаж, хуягийн урдад хоёр суганд давхарлан халхлах хэрэгсэл.

УУДАМДАХ хэтэрхий уудам болох.

УУДАМДУУЛАХ уудамдахын үйлдүүлэх хэв.

УУДАМХАН арай уудам, нилээд уудам.

УУДАМЧ сэтгэл агуу, өршөөнгүй, энэрэлт хүн.

УУДАМЧЛАХ уудамч зан гаргах.

УУДАМШИГ уудам байдалтай, арай уудам.

УУДЛАГДАХ уудлахын үйлдэгдэх хэв.

УУДЛАХ I шингэн зүйлийг нэг савнаас нөгөө сав руу утган авч хийх; *цай уудлах; хөхүүрээс хувинд айраг уудлах.*

УУДЛАХ II 1. авдар саванд байгаа юмыг гаргаж ирэх, авдар савыг нээх, онгойлгох; *авдар уудлах;* 2. уурхай, булш мэтийг онгилон малтах; 3. шилжсэн элдэв хэргийн уг үндэс, нарийн учрыг гаргаж илрүүлэх; *хэргий нь уудлах; уг үндсээр нь уудлах; хоригий нь уудлах;* 4. шилжсэн мөнгө зэргийг үлэмж хэмжээгээр олж авах; *мөнгийг уудалж байв.*

УУДЛУУЛАХ 1. уудлахын үйлдүүлэх хэв; 2. уудлагдах.

УУЖ эхнэр хүний дээлийн гадуур өмсөх, ханцуйгүй урт хувцас.

УУЖИМ 1. уудам, тэлүүн, зай ихтэй, давч биш, явцуу биш; *уудам сайхан нутаг минь; уужим тасалгаа; уужим багтах;* 2. шилжсэн сандруу биш, тавиун, тайван; **уужим саруул** хорш.; *уужим дотортой.*

УУЖИМДАХ 1. хэтэрхий уужим болох; 2. шилжсэн дэндүү тайвандах, дэндүү яаралгүйдэх.

УУЖИМДУУЛАХ уужимдахын үйлдүүлэх хэв.

УУЖИМСГАХ уужимсахын үйлдүүлэх хэв, уужим болгох.

УУЖИМСГУУЛАХ уужимсгахын үйлдүүлэх хэв.

УУЖИМТГАХ уужимтахын үйлдүүлэх хэв, уужимсгах.

УУЖИМТГУУЛАХ уужимтгахын үйлдүүлэх хэв.

УУЖИМХАН баахан уужим, нилээд уужим.

УУЖИМШИГ арай уужим, уужим мэт.

УУЖМАГ эхнэр хүний дээлийн гадуур өмсөх, оноотой, хуниастай хувцас.

УУЖРАЛТ уужрах, тайвшрах үйлийн нэр.

УУЖРАХ 1. уужим болох, намжих; 2. ш и л ж с э н тайвшрах, тайван болох; *дотор уужрах; сэтгэл уужрах.*

УУЖРУУЛАХ уужрахын үйлдүүлэх хэв.

УУЖУУ 1. уужим, уудам, зайтай; **уужуу болох** (зайтай болох); 2. аажуу, яаралгүй; **аажуу уужуу** х о р ш.; *уужуу аажуу ярилцах;* 3. ш и л ж с э н тайван, дөлгөөн; **дотор уужуу болох** (тайвшрах).

УУЖУУХАН 1. баахан уужуу, нилээд уужуу; *уужуухан багтаж байна; уужуухан хөдлөх ёстой;* 2. ш и л ж с э н бэрхшээлгүй, түвэггүй, бардаагаар; *нэгдлийн даргыг ч харин уужуухан хийх хүн байгаа юм.*

УУЛ I 1. эргэн тойрны орчноос дээш өргөгдөн гарсан өндөрлөг газар; **уул нуруу** х о р ш.: *модтой өндөр уул; Богд уул; Алтай уул; уулын чинээ биетэй, туулайн чинээ нүдтэй морь* (үлгэр); *уулын чимэг мод, улсын чимэг эрдэмтэн* з ү й р; **уул завсарлах** (үүрээр тэнгэр уул ялгаварлан үзэгдэх үе); **уул наадах** (уулан дээр хий үзэгдэл үзэгдэх); **уулын таг** (уулын аглаг орой); **уулын цайн цэцэг** у р г а м а л (иш өндөр богино адилгүй, навч цайны навч адил, цэцэг зүйл бүрийн өнгөтэй, улаан нь эрхэм сайн гэнэ); **уулын шаазгай** а м ь т а н (шаазгайтай адил болоод багахан, толгой хар, цагаан сэвхтэй, сүүл урт, сүрэглэн ниснэ, уул шугуйд үлэмж байдаг шувуу); **уулын** ногоодой бялзуухай а м ь т а н (хөхөөний хир биетэй, нүдний зовхиос хоолойд хүртэл хоёр зурвас хар чандар бий, толгой хүзүү ногоон, ар хөх, сүүл бараавтархан нэг зүйл бялзуухай); 2. долоон тооны ёгт нэр

УУЛ II цагаан түрүү, луйль мэтийн ургамлаар хийх, хэт цахиж гал гаргахад хэрэглэх хөвөн мэт зүйл; *хэтний уул.*

УУЛ III угийн, язгуурын; *уул нь энэ хэрэг иймбайжээ;* **уул нутаг** (угийн нутаг).

УУЛАВЧ хэтний уул агуулах сав, хэтэвч.

УУЛАРХАГ уул ихтэй, уулархуу; *уулархаг газар.*

УУЛАРХУУ 1. уулархаг; 2. уул мэт.

УУЛГА I эсэргүүцлийг гэнэт очиж дээрэмдэх цэрэг; **уулга тавих** (тийм цэрэг илгээх); **уулга нь дарагдах** (дажин түйвээний эхний ширүүн үе дарагдах).

УУЛГА II: **уулга алдах** юмнаас сочсон мэт болж хашгирах, элдэв муухай үг хэлэх.

УУЛГАЛАГДАХ уулгалахын үйлдэгдэх хэв.

УУЛГАЛАХ I эсэргүүцлийг гэнэт очиж дээрэмдэх; *уулгалан булаах; уулгалан дайрах.*

УУЛГАЛАХ II уулга алдах.

УУЛГАЛУУЛАХ 1. уулгалахын үйлдүүлэх хэв; 2. уулгалагдах.

УУЛГАМЧ уулга алдамтгай, бэлэнч; *уулгамч хүн.*

УУЛГАМЧЛАХ уулга алдах, бэлэнчлэх.

УУЛГАМЧЛУУЛАХ уулгамчлахын үйлдүүлэх хэв.

УУЛГАР I 1. сандрамхай, хэтэрхий яаруу, тэвдүү; **уулгар дүүлгэр** х о р ш.; *уулгар өвчтэй;* 2. алгасангуй, хайнга, мартамхай.

УУЛГАР II уулын, язгуурын, угийн; *миний уулгар эд.*

УУЛГАХ уухын үйлдүүлэх хэв, уухад хүргүүлэх.

УУЛЗАЛДАХ уулзахын үйлдэлдэх хэв.

УУЛЗАЛТ уулзах, учрах үйлийн нэр; *уулзалт хийх; уулзалтын хурал.*

УУЛЗАМТГАЙ уулзах дуртай.

УУЛЗАР юмны нийлсэн уулзвар газар, *замын уулзар; усны уулзар; хаалганы уулзар, гудамжны уулзар.*

УУЛЗАХ 1. нүүр бие учрах; *нөхөдтэйгөө уулзах; зочидтой уулзах;* 2. хоорондоо нийлэх; *хоёр зам уулзах; гэрийн дээвэр дөнгөж уулзаж байна.*

УУЛЗВАР уулзар, уулзуур.

УУЛЗЛАГА уулзах нь, уулзалт.

УУЛЗУУЛАХ уулзахын үйлдүүлэх хэв.

УУЛЗУУР уулзар, уулзвар.

УУЛЗУУШТАЙ уулзвал зохистой.

УУЛТАЙ уул бүхий.

УУЛЬ а м ь т а н нүд том, хушуу махир, шөнө дуугаран явдаг махчин шувуу; *ухны тулманд ус хийгээд ир, уулийн махыг чанаад идье* (ууль дуугарахад хэлдэг үг).

УУЛЬХАЙ аймтгай, сочимтгой.

УУЛЬХАЙДАХ хэтэрхий уульхай болох.

УУЛЬХАЙЛАХ уульхай зан гаргах.

УУР I шингэн зүйлийн халахад гарах нойтон хий; *усны уур; амны уур; уур манан; уур цан; уурын хүч;* **уурын тэрэг** (а. уурын хүчээр хөдлөх тэрэг, бух тэрэг; б. автомашин); **уурын хөдөлгүүр** (уурын хүчийг механик хүч болгож хувиргах хэрэгсэл); **уурын зуух** (барилга, байшин, орон сууцыг ууранр халаах зуух); **уурын нүх** (уур гарах нүх); **уурын угаал хийх** (халуун ууранр эмчлэх эмчилгээ хийх); **цаг уур, уур амьсгал** (цаг агаарын байдал; *цаг уурын мэдээ; дулаан уур амьсгалтай газар).*

УУР II хилэн, ихэд дургүйцэж хорсох байдал; **уур хилэн** х о р ш.; *уур хүрэх; уур бие зовооно, уул морь зовооно* з ү й р.

УУР III юм хийж нүдэж нунтаг болгох сав; *цайны уур; эмийн уур.*

УУР IV: **уур мэнгэ оор мэнгэ.**

УУРАГ 1. амьтан, ургамлын эсийн бүрэлдэхүүнд орох азоттой шимийн бодис буюу нийлэл; 2. өндөгний доторхи тунгалаг зүйл; *өндөгний цагаан уураг; уураг эд;* 3. нярайлсны даруйд хөхнөөс гарах язмагтай өтгөн сүү; *эхийн шар уураг; анхир шар уургаа шимүүлэн өсгөсөн ачит ээжий минь;* **уураг бөсгөх** (уургийг тусгай саванд хийж чанаж биелүүлэх); **уураг хатаах** (уургийг хайрч боловсруулах); **уураг сүүл** (хонины сүүлийн үзүүрийн хэсэг); **уураг тархи** (гавал дотор байх мэдрэлийн төв тогтолцоо, мөнхүү эрхтнийг бий болгогч бодис).

УУРГА адуу мал барьж авах хэрэгсэл, үзүүртээ хуйвтай урт мод; **уургын морь** (морь уургалахад сургасан морь); *уургаар морь барьдаг, ухаанаар юм бүтээдэг* з ү й р; **уургын улаа** х у у ч и р с а н (алив тохиолдсон адуунаас морь хөсөг барьж хэрэглэх улаа).

УУРГАДАХ уургын улаа хэрэглэн явах.

УУРГАДУУЛАХ уургадахын үйлдүүлэх хэв.

УУРГАЛАГДАХ уургалахын үйлдэгдэх хэв.

УУРГАЛАХ 1. уургаар морь мал барих; *морь уургалах;* 2. уургадах.

УУРГАЛУУЛАХ 1. уургалахын үйлдүүлэх хэв; 2. уургалагдах.

УУРГАЧ 1. уургаар морь мал барихдаа чадамгай хүн; *уургач хүн;* 2. морь мал уургалахад унадаг морь; *уургач морь.*

УУРЛАЛ уурлах үйлийн нэр.

УУРЛАСХИЙХ баахан уурлах.

УУРЛАХ 1. хилэгнэх, уур хүрэх, цухалдах; *худал хэлэв гэж уурлав;* 2. х у у ч и р с а н дотроо муу санах.

УУРЛУУЛАХ уурлахын үйлдүүлэх хэв, ууры нь хүргэх.

УУРС I эд, юм, зөөр; **эд уурс** х о р ш.

УУРС II тогоруу шувуу.

УУРСАХ I уурлах байдал илрэн мэдэгдэх.

УУРСАХ II уур болох; *ус уурсах.*

УУРСУУЛАХ уурсахын үйлдүүлэх хэв.

УУРТ уур бий.

УУРТАЙ уур бүхий, уур ихтэй; *ууртай царай гаргах.*

УУРХАЙ 1. эрдэнийн чулуу, алт, төмөр, нүүрс зэрэг малтмалын зүйл гарах газар, орд; *чулуун нүүрсний уурхай; алтны уурхай;*

уурхайн үйлдвэр (уурхайн баялгийг авах, боловсруулах үйлдвэр); **уурхайн ажилчин** (уурхайн үйлдвэрт ажилладаг ажилчин); 2. тоосго, ваар мэтийг түлж бэхжүүлэх зоорь нүх; 3. шүдний ургах хонхор; *шүдний уурхай;* 4. ш и л ж с э н хэрэг явдлын уг үндэс, сурвалж, үүр; *хэргийн уурхайг уудлах.*

УУРХАЙЧ уурхайн ажилчин.

УУРШИХ уур болох.

УУРШМАЛ ууршсан юм.

УУРШУУЛАХ ууршихын үйлдүүлэх хэв.

УУСАХ шингэн бодисын дотор хайлах; *давс уусах; ажил хийвэл дуустал, давс хийвэл уустал* з ү й р; **уусах чанар** (шингэн бодисын дотор хайлах чанар).

УУСАХГҮЙ үл уусах, хайлахгүй.

УУСВАР уусах байдал чанар.

УУСВАРГҮЙ уусах нь муу, уусахдаа муу.

УУСВАРТАЙ уусахдаа хялбар, түргэн амархан хайлдаг.

УУСГАМАЛ хатуу, шингэн эсвэл хийн байдалтай бодисыг шингэн бодистой холиход бий болох шингэн зүйл.

УУСГАХ уусахын үйлдүүлэх хэв.

УУСГУУЛАХ уусгахын үйлдүүлэх хэв.

УУСМАЛ ууссан юм.

УУТ юм агуулахын тулд эд бөс, эсгий мэтийн зүйлээр хийсэн сав, хүүдий; *эсгий уут; дэркий уут; хурганы уут.*

УУТАНЦАР жижиг уут.

УУТАЧ хүний хулуусан юмыг учир мэдэлцэн авч шингүүлэх этгээд.

УУТЛАХ 1. уут дотор агуулах; 2. ш и л ж с э н уудлах, их авах.

УУТЛУУЛАХ уутлахын үйлдүүлэх хэв.

УУХ I 1. шингэн юмыг балгаж залгих; *цай уух; уух ус; үхэр ус ууж байна; шөл уух;* 2. ш и л ж с э н шингээх; *бэх уудаг цаас.*

УУХ II х у у ч и р с а н шингэн юмыг уудлах.

УУХАЙ 1. сур, шагаа харвахад хэлэх аялга; *сурын уухай;* 2. байлдаанд дайран ороход хашгиран өгүүлэх аялга; *урвасан хулгай Найдан ванг уухай хийгээд дайрав* (дуу); 3. сэтгэлд тааламжтай байгааг илтгэх аялга; *за, уухай; уухай, тийм үү; уухай даа!*

УУХАЙЛАХ уухай хийх.

УУХАЙЛУУЛАХ уухайлахын үйлдүүлэх хэв.

УУХАЙЧИН уухай хийгчид.

УУХАН баахан уу; *уухан цагаан тархиндаа, ардын хувьсгалыг шингээе, бэлхнээ* (пионерийн дуу).

УУХИЛАХ түргэн ширүүн амьсгалах; **аахилах уухилах** х о р ш.; *давхиж ирсэн морь уухилж байв.*

УУХИЛУУЛАХ уухилахын үйлдүүлэх хэв.

УУХИРАХ бархиран түйвээх.

УУХИРУУЛАХ уухирахын үйлдүүлэх хэв.

УУЦ 1. нурууны сээрээс ахар сүүл хүртлэх хэсэг, харцага; *учир мэдэхгүй хүнд, ууц бүү гарга* з ү й р; **ууцаа үүрэх** (хоёр гараа ар ңуруунд зөрүүлэн тавих); 2. монгол үндэсний идээ болох, нядалсан хонины нурууны сээрээс доош бүхий бүх хэсэг: *ууц тавих;* **ууц таллах** (ууцны хоёр этгээдийн намилхайг нимгэн нимгэн зүсэх).

УУЧ санаа мэдэл агуу их, өршөөнгүй, энэрэлтэй.

УУЧЛААЧ өршөөнгүй, энэрэлтэй, сэтгэл зөөлөн.

УУЧЛАГДАХ уучлахын үйлдэгдэх хэв.

УУЧЛАЛ уучлах үйлийн нэр, өршөөл, энэрэл.

УУЧЛАХ өршөөх, хэлтрүүлэх, хөнгөтгөх; *та уучлаарай, би таныг буруу таньжээ; ялыг уучлах; амийг уучлах.*

УУЧЛАШГҮЙ уучлах арга байхгүй, уучилж болохгүй.

УУЧЛУУЛАХ 1. уучлахын үйлдүүлэх хэв; 2. уучлагдах.

УУШ уух юм; **идэш уух** х о р ш.;*идэш уушны дэлгүүр.*

УУШГИ амьтны амьсгалын эрхтэн; *уушги үрэвсэх; уушгины өвчин; маргаашийн өвхнөөс өнөөдрийн уушги дээр* с э ц э н үг; **уушгины сүрьэ** (өвөрмөц бичил нянгаас үүсэх уушги-

ны халдварт өвчин); **уушгин чулуу** (галт уулаас гарсан хөнгөвтөр, нүхэрхэг чулуу, бас хүрмэн чулуу, хүрмийн чулуу ч гэнэ) [illegible]

УУШИГ уушги.

УХАА I 1. цайвардуу гэрэлтэй улаан өнгө; *ухаа хонгор морьтой доо, улсын их жанжин даа* (дуу). [illegible]

УХАА II талархуу газар буй өндөрхөн зоо газар.

УХАА (Н) III оюун, бодлого; **ухаан ихтэй** (мэргэн, сэцэн, бодлого сайтай); **ухаан гаргах** (мэргэн санаа гаргах); **ухаан сум** (юмыг үлгэрлэх, жиших зэргээр зөв зүйг бодолхийлж олох бодлого); 2. мэдрэл; **ухаан мэдрэл, ухаан сэхээ** х о р ш.; **ухаан алдах** (а. муужран унах; б. тэсвэрлэж ядах, байж ядах; в. ихэд айх); **ухаан орох** (а. муужраад дахин сэргэх; б. хүүхэд багачуудын учир мэдэх болох; в. мэдэхгүй юмыг бодолхийлж олох); **ухаан гарах** (ихэд айх); **ухаан балардах** (элий балай болох); **ухаан жолоогүй** (оюун бодлын хир хэмжээ алдрах; *хүүдээ ухаан жолоогүй хайртай байв; ухаан жолоогүй хурдан давхих*); **ухаан муудах** (а. тэнэг мангуу, уймраа болох; б. мэдрэл муудах); **ухаан заах** (а. арга сүвэгчлэх; б. оюун бодлоор давуу болохоо үзүүлэх); **нарийн ухаан** (мэргэн арга); **хар ухаан, бүдүүн ухаан** (туршлага, ердийн бодол); **ухаан гаргах, ухаан зарах** (а. оюун бодлоо дайчлах; б. нарийн арга олох: в. заль мэх гаргах); 3. судлал, сургаал, шинжлэл, онол; **шинжлэх ухаан** (байгаль, нийгэм, сэтгэхүйн хөгжлийн зүй тогтоолыг судлах сургаалуудын тогтолцоо мөн тийм сургаалуудыг тус тусад нь нэрлэх нэр); **гүн ухаан** (байгаль, нийгэм, сэтгэхүйн хөгжлийн ерөнхий хуулиудыг судлах сургаал); **сурган хүмүүжүүлэх ухаан** (сургаж хүмүүжүүлэх тухай онол; *сурган хүмүүжүүлэх ухааны дэд эрдэмтэн*); **анагаах ухаан** (аливаа өвчин, тэдгээрийг эмчлэх мөн урьдчилан сэргийлэх тухай сургаалын цогц); **химийн ухаан, хувилахуй ухаан** (материйн дотоод бүтэц, дотоод байгууллыг судлах мөн бодисын хувирах, өөрчлөгдөх, задрах, чанарын хувьслаас шинэ бодис үүсэн бий болох зүй тогтоолыг судлах сургаал бөгөөд байгалийн шинжлэх ухааны үндсэн зүйлүүдийн нэг болно); 4. ш и л ж с э н учир, шалтгаан; *ямар ухаантай юм бэ, мэдэхгүй.* [illegible]

УХААГНАХ ухаалах, ухаачлах. [illegible]

УХААГЧ ухаа зүстэй эмэгчин мал; *ухаагч үнээ; ухаагч гүү.* [illegible]

УХААЛАГ ухаан сайтай, сэргэлэн, авьяаслаг. [illegible]

УХААЛАХ ухаан гаргах, арга гаргах; *ухаалж бодох.* [illegible]

УХААЛУУЛАХ ухаалахын үйлдүүлэх хэв. [illegible]

УХААНГҮЙ 1. ухаан муутай, мангуу, мунхаг; *яасан ухаангүй амьтан бэ чи;* 2. ухаан алдсаны нь; *ухаангүй хэвтэж байв;* 3. ш и л ж с э н сүйд майд, ухаан алдам; *хүүхэдтэйгээ уулзах гээд ухаангүй явна.* [illegible]

УХААНТАЙ 1. ухаан сайтай, сэргэлэн; *ухаантай хүүхэд; ухаантай хүнийг үгээр, ууртай хүнийг эвээр* з ү й р; 2. ухаан эрүүл, согтуу биш; 3. учиртай. [illegible]

УХААРАГДАХ ухаарахын үйлдэгдэх хэв. [illegible]

УХААРАЛ ухаарах үйлийн нэр. [illegible]

УХААРАХ I юмны учир ухааныг олох, ойлгох; *одоо сая ухаарч байна.* [illegible]

УХААРАХ II ухаа өнгө зүстэй болох; *ухааран харагдах.* [illegible]

УХААРУУЛАХ ухаарахын үйлдүүлэх хэв. [illegible]

УХААРХАГ ухаархуу, ухаалаг, ухаан ихтэй. [illegible]

УХААРХАХ ухаантайдаа бардам зан байдал гаргах. [illegible]

УХААРХУУЛАХ ухаарахын үйлдүүлэх хэв. [illegible]

УХААРШГҮЙ ухаанд оршгүй, ухаарч болшгүй. [illegible]

УХААЧЛАХ ухаалах, ухаан бодлого гаргах. [illegible]

УХАГДАХ I 1. ухахын үйлдэгдэх хэв; 2. малтагдах. [illegible]

УХАГДАХ II 1. ухахын үйлдэгдэх хэв; 2. ухаарагдах, ойлгогдох. [illegible]

УХАГДАХГҮЙ ухааратдахгүй, учир нь сайн мэдэгдэхгүй. [illegible]

УХАГДАХУУН ухахад өртөгдөх юм, мэдэгдэхүүн. [illegible]

УХАЛ мэдлэг, мэдэл, ухвар. [illegible]

УХАМ ухмал, ухсан нь; **ухам им** (малын чихний дугуй им). [illegible]

УХАМЖ ухвар. [illegible]

УХАМЖЛАХ ухаарах, ухварлах. [illegible]

УХАМСАР 1. ухвар, ухаан; *ухамсар сайтай; ухамсар муутай;* 2. эргэн тойрны байдлыг зөв танин ухварлах мэдлэг; *улс төрийн ухамсар; ангийн ухамсар.* [illegible]

УХАМСАРГҮЙ ухамсар мэдлэг муу дорой, ухамсар суугаагүй.

УХАМСАРЛАХ учир утгыг ойлгож танин авах.

УХАМСАРЛУУЛАХ ухамсарлахын үйлдүүлэх хэв.

УХАМСАРТАЙ ухамсар, ухаан мэдлэг сайтай.

УХАМТГАЙ I ухах төнхөхдөө дадамгай, дуртай.

УХАМТГАЙ II ухаж мэдэхдээ дадамгай.

УХАР этүүр халбага.

УХАРХАЙ гавлын ясны нүд орших хонхор, мөн чамархайн дотоод дахь хонхор; *нүдний ухархай; ухархайгий нь ухах; ухархайгаар өвдөх.*

УХАС: ухас ухас хийх урагш гэнэт гэнэт тэмүүлэх.

УХАСХИЙЛГЭХ ухасхийхийн үйлдүүлэх хэв.

УХАСХИЙХ 1. гэнэт урагш түргэн давхийн хөдлөх; *буу ч тасхийв, би ч ухасхийв* (гөрөөчний домог); *морио ухасхийхэд бүүрэгнээсээ ухасхийн барив; нохой, морьтой хүн рүү ухасхийв;* 2. ойрхон зуур давхин хүрэх; *чи ухасхийгээд ир дээ*

УХАХ I 1. малтах, сэндлэх; *нүх ухах; шуудуу ухах; худаг ухах;* 2. онгилох, төнхөх; *гансны толгой ухах;* 3. шилжсэн уудлах, онгилох; *хүүдий ухах; авдар саваа ухаж ухаж олсонгүй;* 4. дугуй хэлбэртэй огтлон авах; *дээлийн зах ухах; дээврийн хоолой ухах.*

УХАХ II ойлгох, ухамсарлах; *ухаж мэдэх; ухахад бэрх.*

УХВАР мэдэх, ойлгох ухаан; *ухвар сайтай;* **ухвар мөчид** (ухамсар дутуу).

УХВАРГҮЙ ёс зүйг мэдэхгүй, мунхаг.

УХВАРЛАХ ухаарч мэдэх, учир чанарыг танин ойлгох, ухамсарлах.

УХВАРЛУУЛАХ ухварлахын үйлдүүлэх хэв.

УХВАРТАЙ ухвар бүхий, ухвар мэдлэг сайтай.

УХДАС ухлаадас.

УХИАЛ ухиах үйлийн нэр; *ухиал хийх;* **ухиалын гадар** (нүүр угаах сав); **ухиалын тэвш** (бие угаах сав.

УХИЛАМТГАЙ уйламтгай.

УХИЛАМХАЙ уйламхай.

УХИЛАХ уйлах.

УХИЛУУЛАХ ухилахын үйлдүүлэх хэв.

УХИРАЛТ ухрах үйлийн нэр, ухрах үйлийн явц; ухралт.

УХИРАХ ухрах, хойш эгсхийх, буцах, няцах, хойш суух; *машин ухирах; цэрэг ухирах; ажлаас ухирах; хэлснээсээ ухирах.*

УХИРУУЛАХ ухирахын үйлдүүлэх хэв.

УХЛААДАС ямар нэгэн юм хийхдээ тэр юмнаас ухаж авсан хэсэг; *захны ухлаадас; дээврийн ухлаадас; модны ухлаадас.*

УХМАЛ ухсан юм; *ухмал онгоц; ухмал нүх; ухмал үүр.*

УХМАЛЛАХ ухаж үйлдэх, ухмал болгох.

УХМИ юмны дотоодыг ухаж засах махир үзүүртэй зэвсэг.

УХМИДАХ ухмиар ажиллах.

УХМИДУУЛАХ ухмидахын үйлдүүлэх хэв.

УХНА хөнгөлж засаагүй эр ямаа; **ухна тавих** (ухна болгохоор засахгүй орхих).

УХНАСАХ эм ямааны ухна эрэх.

УХНАТАХ ухнын эм ямаа хөөх; 2. ерийн ямааны ухна мэт аашлах.

УХРААЛГАХ ухраахад хүргүүлэх, гэдрэг болгуулах, буцаалгах.

УХРААХ ухрахад хүргүүлэх, гэдрэг болгох, буцаах; *машинаа жаахан ухраагаач.*

УХРАХ 1. гэдрэг явах, ухирах; *тэрэг ухарч байна; ухрах араа;* 2. шилжсэн няцах, үл зориглох; зориглосноосоо буцах.

УХРУУЛАХ ухрахын үйлдүүлэх хэв.

УХУУЛАГЧ ухуулах, сэнхрүүлэх үйлийг гүйцэтгэгч; *намын ухуулагч; хэсгийн ухуулагч; ухуулагчийн өврийн дэвтэр; ухуулагчийн тусламж.*

УХУУЛАХ I ухах I-ийн үйлдүүлэх хэв; *худаг ухуулах.*

УХУУЛАХ II ухах II-ын үйлдүүлэх хэв, сэнхрүүлэх, мэдрүүлэх, таниулах; *ухуулан таниулах ажил; учрыг ухуулан хэлэх;* **ухуулах бичиг** (нийтээр сэнхрүүлэн тунхаглах бичиг); **ухуулах хуудас** (ухуулах ажилд хэрэглэх бичиг, зураг бүхий хуудас).

УХУУЛГА 1. ухуулах үйлийн нэр; сэнхрүүлэн таниулах нь; *ухуулгын ажил;* 2. ухуулах бичиг; *ухуулга наах; ухуулгын ажил хийж явна.*

УХУУР юм ухах зэвсэг; *чихний ухуур; мөөгний ухуур; ухуур хутга; ухуур мод төмөр.*

УХЧЛАХ I 1. мал адгуусны хөлөөр шороо маажлах, малтах; *хонь ямаа үндэс ухчилж байна;* 2. ш и л ж с э н бусдын өө сэвийг эрэлхийлэн гаргах; *бусдын дутагдлыг ухчлан илрүүлэх.*

УХЧЛАХ II байн байн хянан ухах; *ухчлан бодож байж хариу өгье.*

УХЧЛАГДАХ ухчлахын үйлдэгдэх хэв.

УХЧЛУУЛАХ 1. ухчлахын үйлдүүлэх хэв; 2. ухчлагдах.

УЦААР муухай ааштай, чухалдуу, ууртай; *уцаар ааштай; удаан цаг өвчтэй байгаад уцаар болсон байв.*

УЦААРЛАХ уцаар зан авир гаргах; *юм асуухад уцаарлах.*

УЦААРЛУУЛАХ уцаарлахын үйлдүүлэх хэв.

УЧИГ I 1. юм оёж байсан зүүнд сүвлээтэй байгаа утас; **учиг шингээх** (зүүнд байгаа утсыг барагдтал оёх); 2. зүүнд сүвлэхээр гаргасан утсаны нарийн үзүүр; **учиг гаргах** (утсыг зүүнд сүвлэхээр үзүүр гаргах).

УЧИГ II төл хөхсөнний дараа дэлэнд үлдсэн сүү.

УЧИГЛАХ I сүвэгч гарах утсанд үзүүр гаргах.

УЧИГЛАХ II учгийг саах; *үнээ учиглах.*

УЧИР 1. шалтгаан, байдал: **учир шалтгаан, учир байдал, учир утга, учир ухаан, учир чанар** х о р ш.; *ийм учиртай хэрэг; учир юу вэ гэвэл... учир утгагүй юм гэж байх ёсгүй, эрхбиш нэг л учир утгатай байх ёстой; юманд учир бий, модонд мөчир бий* з ү й р; **учры нь олох** (а. шалтгаан байдлы нь мэдэх; *учры нь олж хужры нь тунгаах* з ү й р; б. ш и л ж с э н нэгэн тийш болгох, дуусгах); **учир мэдэх** (а. юмны шалтгааныг мэдэх; б. ш и л ж с э н хуйвалдах); **учир зүггүй** (маш их; *учир зүггүй загнах; учир зүггүй үнэ дуудаж байна; учир зүггүй баярлаж байгаа бололтой*); **учир нажиргүй** (а. юмны байдал шалтгааныг үл харгалзах; б. эмх замбараагүй); **учир шалтгааны ухаан** (сэтгэхүйн хууль болон түүний хэлбэрийн тухай шинжлэх ухаан, логика); 2. тавилан, хувь, учрал; *хэрэв уулзах учир байвал...* 3. тул; *утас явуулсан учир захидал бичих хэрэггүй; тэр намайг мэдэх учир итгэх биз ээ;* 4. энэ тухай; *би энэ асуудлын учир танилцах гэж биеэр хүрэлцэн ирэв; энэ ургамлын учрыг сайн мэднэ;* 5. ёс; **учир ёс, учир зүй** х о р ш.; *хэрэв ёс хэлэлцвэл ийм учир бий.*

УЧИРГҮЙ 1. учир шалтгаан байхгүй; *тэр чамд хар хор санах учиргүй; тийм учиргүй юм гэж яаж байх вэ;* 2. маш их; *учиргүй үнэтэй морь; учиргүй хэрэгтэй юм; учиргүй баярлажээ; учиргүй уйлав.*

УЧИРЛАЛ учирлах үйлийн нэр.

УЧИРЛАХ учир шалтгааныг тооч их, учир гаргах; *учирлаж гүйх; учирлаж хэлэх.*

УЧИРЛУУЛАХ учирлахын үйлдүүлэх хэв.

УЧИРТАЙ учир шалтгаан бүхий; *энэ яасан ч нэг учиртай ирсэн биз; энэ чулуу заавал нэг учиртай даа; энэ өдөр тэр манайд ирэх учиртай; юм учиртай, мод мөчиртэй* з ү й р.

УЧИРТАЙХАН арай учиртай, баахан учиртай; *үүнийг учиртайхан бодно биз.*

УЧРАА учрах юм, учрал; *энэ бөхийн учраа хэн бэ? учраа сайтай; учраа муутай.*

УЧРАЛ учрах үйлийн нэр; 1. тохиол, учрах тавилан; *ингэх учрал байж даа; учрал байвал эдэлнэ;* 2. учрах нь, уулзах нь; *баяртай учрал; уулзахын учрал.*

УЧРАЛТ учрал бүхий, тохиол бүхий, тавилант; *учралт амраг.*

УЧРАХ уулзах, тохиолдох, дайралдах; *надтай зах дээр учрав; ийм их гарз учрах гэж*

байх уу? би бөөн гайд учирлаа; зовлон учрах; саад учрах; амрагтайгаа учрах; **нүүр учрах** (биеэр уулзах).

УЧРУУЛАХ учрахын үйлдүүлэх хэв, учрахад хүргүүлэх.

УЮУЛАХ уяхын үйлдүүлэх хэв.

УЯА 1. морь малыг уяж тогтоохоор бэлдсэн юм, хоёр буюу хэд хэдэн мод шон босгож зэл татаж хийх, ганц мод босгож хийх ч бий; *морины уяа;* 2. нохой ба малын зэрэг амьтныг уях нарийн төмөр буюу олс дээсний зэрэг юм; *нохойн уяа;* 3. хулгайч нарын бэрх уул хад, мод мэтэд хулуусан малыг нуун далдалж хадгалах нууц чухал газар; *хулгайчийн уяа;* **уяаны морь** (а. наадамд уралдуулахаар уяж байгаа хурдан морь; б. албан ажилд хэрэглэхээр бэлтгэсэн морь).

УЯАС уясан зангидсаны нь; *уяасы нь чангал.*

УЯАТАЙ уяа бүхий; *уяатай тугал; уяатай нохой урчих магадгүй, мэдэж яв!*

УЯАЧИН уяаны морийг эзэмшин хариуцах хүн.

УЯАШИХ уядаа харшиж ядрах.

УЯАШРАХ уядаа харших шинж орох.

УЯДААХ уядахад хүргүүлэх.

УЯГДАХ уяхын үйлдэгдэх хэв, хойшлогдох; *ажил уягдах.*

УЯДАХ хэтэрхий уян болох.

УЯДУУЛАХ уядахын үйлдүүлэх хэв.

УЯЙ: уяй загас амьтан бие тулын адил болоод цагаан эрээн алаг бий, урт нь дөрвөн төө илүү, далайд оршино.

УЯЛГА уях үйлийн нэр, уяа; *уялга нь таарлээ; уялга татлага сайтай байна;* **уялга үг** (бичиг зохиол, хэрэг явдлын өмнө зорьсон санаг заан гаргаж хураангуйлан бичсэн товч үг); **уялга төмөр** (юм уяхад зориулж хийсэн гогцоо мэт төмөр).

УЯЛГАЛАХ бичиг зохиолын өмнө хураангуй үг сэдэвлэн гаргах.

УЯЛДАА холболдоо, авцалдаа, зохицолдоо; *хоорондоо ямар ч уялдаа байхгүй байна.*

УЯЛДАХ 1. уяхын үйлдэлдэх хэв; 2. үйл явдлын харилцан холболдож нийцэх барилдах; *хоорондоо уялдах; урьдахь ажилтайгаа уялдахгүй байна.*

УЯЛДУУ 1. үг өгүүллийн зөөлөн ялгуум; 2. хатсан юмны дэвтэж зөөлөрсний нь.

УЯЛДУУЛАХ 1. уялдахын үйлдүүлэх хэв; 2. юмыг уялдуу болгох.

УЯЛЦАХ уяхын үйлдэлцэх хэв.

УЯЛЦУУЛАХ уялцахын үйлдүүлэх хэв.

УЯМАН хулгана өвчний өөр нэр.

УЯН 1. аливаа юмны зөөлөн, нугарахдаа хялбар; *уян төмөр;* **уян хатны нь тохируулах** (хатуу зөөлний нь тааруулах); 2. шилжсэн сэтгэл зөөлөн; *уян сэтгэлтэн;* **уян зан** (зөөлөн зан); **уян санаа** (өрөвч санаа).

УЯНГА 1. дуу чимээний маш тааламжтай; 2. бичиг зохиолын найруулга уран сайхан; **утга уянга** (яруу найргийн нэг зүйл; *утга уянгын шүлэг).*

УЯНГАЛАХ юмыг уянгатай болгох.

УЯНГАЛУУЛАХ уянгалахын үйлдүүлэх хэв; *уянгалуулан дуулах.*

УЯНГАТ уянгатай; **уянгат мод** ургамал (уул довд ургана, маш өндөр, мах судал нарийн цул, өнгө шар нэг зүйл мод).

УЯНГАТАЙ уянга бүхий; *уянгатай дуу; уянгатай хөгжим.*

УЯРАЛ уярах үйлийн нэр.

УЯРАЛТАЙ 1. сэтгэл уярам; 2. гашуудсан хаширсан хүн.

УЯРАХ 1. хайрлан гомдож сэтгэл эвдрэх; *дотор уярах; сэтгэл уярах;* 2. уятах, зөөлөн болох.

УЯРУУЛАХ 1. уярахын үйлдүүлэх хэв, уярахад хүргүүлэх; 2. зөөлөн болгох; *болд уяруулах.*

УЯСАХ уян болох, уятах.

УЯСГАХ уясахын үйлдүүлэх хэв.

УЯТАЙ юмны уян зөөлний нь.

УЯТАХ 1. уян байдалтай болох, хатуу чанга юмны өчүүхэн зөөлрөх, сулрах; 2. дангинатал хөлдсөн юмны баахан гэсэхийх; 3. агиран хатсан юмны баахан дэвтэх; 4. хатан төмрийн баахан зөөлөн болох; 5. тэсгим хүйтний хүч баахан сулрах.

УЯТГАХ уятахын үйлдүүлэх хэв.

УЯХ 1. зангилах, зангидах, зангидан бэхлэх, тогтоох; *өрхний оосор уях; гутлын оосор уях;* **уян татах** (хуумгай уях); 2. юмыг оосроор бэхэлж тогтоох; **морь уях** (а. морийг уяанд бэхлэн тогтоох; б. хурдны морийг уралдуулахад бэлттэн засах); 3. ш и л ж с э н хэрэг явдлыг удаашруулах; *явдал уях; чи битгий ажил уяад бай!*

УЯХАН баахан уян, нилээд уян; *уяхан сэтгэл; уяхан төмөр.*

Ү

Ү ү үсэг, ү авиа.

ҮВТЭГШ туйлын эрхэм, үнэхээр, хэтэрхий; *үвтэгш сайхан; үвтэгш гайхамшиг; үвтэгш баялаг.*

ҮГ 1. ухагдахууныг илтгэхэд хэрэглэх ярианы нэгж; *үгийг үе болгож хуваах;* **үгийн гарал** (аливаа үгийн үүсэл; *үгийн гарал судлал*); **үгийн язгуур** (үгийн цэвэр үндэс буюу цааш утга бүхий хэсгээр задалж үл болох хэсэг); **үгийн үндэс** (үгийн үндсэн утга заах хэсэг буюу үг зүйн ёсоор янз бүрийн дагавар залгаж цаашаа хувилгаж болох хэсэг); **үгийн баялаг** (үгсийн сан; *үгсийн баялгийг судлах*); **үг зүй** (үгийн бүтэц судлал); 2. хэлсэн зүйл, яриа, сургаал заавар; **үг хэл, үг яриа** х о р ш.; *хурал дээр хэлсэн үг; үг мэдэхгүй сүрхий хүн байна даа; үг хэлэх зөвшөөрөл авах; төгсгөлийн үг, хэрэгтний эцсийн үг; үг дуугүй бууж өгөх; муу үг, модон улаатай* з ү й р; *үг олдож, үхэр холдох* з ү й р; **их үг хэлэх** (хэгжүүн хэвлүүн зан гаргах); **уран үг** (гоё үг); **үгээр дайрах** (хүнийг муу үгээр басамжлан хэлэх); **үгний домог болох** (олонд шоологдох); **ширүүн үг хэлэх** (зандрах, зэмлэх); **зөөлөн үг** (аргадсан үг); **муу үг** (а. тааламжгүй үг: б. муу чимээ, мэдээ); **эгзэгтэй үг** (а. өө сэвий нь олж хэлсэн үг; б. далдуур егсөн, ёжсон үг); **үг гаргах** (хэл өгүүлэл гаргах); **үг авах** (а. аливаа ам хэлүүлж авах; б. үгэнд орох, хэлсэн сургасныг ойшоох; *тэр хүү чинь үг авахдаа сайн хүүхэд байгаа юм*); **үг алдах** (хэлбэл зохисгүй үгийг бусдад санамсаргүй хэлэх); **үг дуулах** (а. үгийг сонсч хүлээн авах; б. үгэнд орох; *үг дуулдаг хүүхэд байгаа юм*); **үгээр үг хийх** (бусдын хэлсэн ерийн үгийг өөнтөг санаж хэрэг болгон ярих); **үгэнд дуртай** (а. бусдын яриаг сонсохдоо дуртай: б. бусдын үгийг сонсож дамжуулах дуртай); **үг өгөх** (а. амлах, ам тангараг өгөх; б. дохио болгож сануулах); **үгэндээ хүрэх** (хэлсэн үгээ ажил болгох); **зүйр үг** (ардын аман зохиолын нэг төрөл, амьдралын үзэгдэл байдлыг зүйрлэн жишсэн бөгөөд чимэгтэй, нухаштай цөөн үгээр онож шүлэглэсэн хэллэг); **цэцэн үг** (ардын аман зохиолын нэг төрөл, амьдралын явцад ажиглаж дүгнэсэн зүйлээ оновчтой цөөн үгээр шүлэглэсэн утга төгс хэллэг); **хууч үг** (ардын аман зохиолын нэг төрөл, эрт дээр цагаас уламжилж ирсэн аж амьдралын тухай цөөн үгээр шүлэглэсэн сургамжит хэллэг); **сургаал үг** (ардын аман зохиолын нэг төрөл, аж амьдралд сануулах, сургамжлах, ятгах, хориглох санааг илэрхийлж цөөн үгээр шүлэглэсэн сургаалт хэллэг); **үг булаалдах** (маргалдах); **үг дагуулах** (хэлсэн ярьсныг аялдан дагаж зөвшөөрөх); **үг үсэгчлэн** (үг нэгбүрчилэн, утга үл харгалзан: *үг үсэгчлэн цээжлэх*); **үг таслах** (ярихыг болиулах); **үг өөлөх** (буруу хазгай хэлснийг далимдуулан муучлах); **үг гээдэггүй** (хэлсэн ярьсан бүхнийг өлгөн авч өөлөх); 3. дуу дуулахад хэлэх зүйл, утга; *төрийн дууллын үг; дууны үг*).

ҮГДЛҮҮЛЭХ үгдлэхийн үйлдүүлэх хэв.

ҮГДЛЭХ өвчнийг үгдрэх, хүндрэхэд хүргүүлэх.

ҮГДРҮҮЛЭХ үгдрэхийн үйлдүүлэх хэв.

ҮГДРЭХ өвчин ялаарь болох тийш хандаж байгаад дахин хүндрэх; *ханиад үгдрэх.*

ҮГДРЭЭХ үгдрэхэд хүргүүлэх, үгдрүүлэх.

ҮГДЭРГЭХ үгдрүүлэх, үгдрээх.

ҮГИЙГҮҮ үгээгүү.

ҮГИЙГҮҮРЭХ үгүйрэх.

ҮГИЙГҮҮЯА үгүй хоосон.

ҮГИЙРҮҮЛЭХ үгийрэхийн үйлдүүлэх хэв.

ҮГИЙРЭЛ үгийрэх үйлийн нэр; **үгийрэл хоосрол** х о р ш.; *үгийрлийн туйлд хүрэх.*

ҮГИЙРЭХ хоосрох, барагдах.

ҮГИЙСГҮҮЛЭХ үгийсгэхийн үйлдүүлэх хэв.

ҮГИЙСГЭЛ үгнйсгэх үйлийн нэр; *үгийсгэлийн тэмдэг.*

ҮГИЙСГЭХ бий бүхий юм, чухал зүйлийг үгүйд үзэх; *манай хөгжил цэцэглэлийг үгийсгэх; юмыг яаран үгийсгэж үзэх нь буруу,* **үгийсгэх үзэл** (орчин ахуйн бодит үнэнийг үгүйд үзэх идеалист үзэл); **үгийсгэх үзэлтэн** (үгийсгэх үзлийг баримтлагчид).

ҮГЛҮҮЛЭХ үглэхийн үйлдүүлэх хэв.

ҮГЛЭХ I 1. алба, тушаалаас чөлөөлөх, хэлтрүүлэх, хөнгөтгөхийг гуйх; *алба үглэх; тушаал үглэх;* 2. яншин, нуршин зэмлэж авд үл зогсох; *их үглэдэг хүн; үглээд салдаггүй; аман дотроо үглэх.*

ҮГЛЭХ II гөрөөсийг тоттоохын тул аялгуу, чимээ гаргах.

ҮГС олон үг; *үгсийн тайлбар; утга хуучирсан үгс;* **үгсийн сан** (үгсийн бүрэлдэхүүн); **үгсийн бүрэлдэхүүн** (аливаа хэлний бүх үгсийн цогц); **үгсийн үндсэн сан** (аливаа хэлний үгсийн бүрэлдэхүүнд гол үндэс болж ордог үгс); **үгсийн аймаг** (үгсийн хэл зүйн ангилал).

ҮГСРЭХ I амрах тусам дахин алжаангуй болох; *бие хүндэрч үгсрэх.*

ҮГСРЭХ II 1. юмны гутаж чанараа алдах, үгшрэх; *үгсэрсэн эд бараа;* 2. ягшрах, нэвсрэх; *үгсэртэл баримтлах; үгсэртэл унтах.*

ҮГСҮҮЛЭХ үгсэхийн үйлдүүлэх хэв.

ҮГСЭЛ үгсэх үйлийн нэр, харилцан хэлэлцэж үг санал нийлсэн зохицол; *үгслээр үйлдэх; үгслээр нийлэх.*

ҮГСЭХ I зөвшөлдөх, харилцан санал тохирох, нийлэх.

ҮГСЭХ II ургамал зэрэг юмны хатаж, гутаж чанараа алдах; *өвс үгсэх; мах үгсэх; үгсэн ургамал; үгсэн байцай.*

ҮГТ үгз; *үгт татах; үгт эчих;* ☆ **үгт болох** (идэш хоол шингэхгүй давхцах гэм олох).

ҮГТЭЙ үг бүхий; *гучин мянган үгтэй толь.*

ҮГТЭЭХ чангаах, татах, үгзрах; *мөчрөөс нь үгтээх; үндэснээс нь үгтээх; гараас нь үгтээх.*

ҮГҮЙ 1. бий гэдгийн эсрэг үг; *бий үгүй хоерыг мэдэхгүй; үгүй юм үхрээс хашин;* **үгүй болох** (а. алга болох; б. цээрлэсэн үхэх); **үгүй хийх** (а. юмыг үгүй болгох, алга болгох; б. цээрлэсэн үхүүлэх): 2. үл ахуу; *гэрт хүн үгүй байв; ганц ч улаан мөнгөгүй гарав; үгүй байх;* 3. хоосон, ядуу; **үгүй хоосон, үгүй ядуу** хорш.; *үгүйн зовлон хэцүү;* 4. үгтэй хамтран орж тухайн үгийн үгүйсгэх санааг заана; *би өнөөдөр юм үзэхгүй; би явахгүй, эндээ л байна; уулгүй талд усгүй цөлд, засаггүй ноён цусгүй дайтна* оньсго; 5. татгалзах санаа; *—үгүй би заавал явна; —чи хөдөө явах уу? —үгүй; чи өнөөдөр хөдөө явах юмуу; үгүй юу? —үгүй, би явахгүй;* 6. эсрэг утгатай хоёр үгийн сүүлийн үгтэй нийлж бүх, цөм, бүгд гэсэн утга илэрхийлнэ; *хот хөдөөгүй; өвөл зунгүй; өглөө үдэшгүй; сайн муугүй; хөгшин залуугүй эр эмгүй; энд тэндгүй.*

ҮГҮЙДҮҮЛЭХ үгүйдэхийн үйлдүүлэх хэв.

ҮГҮЙДЭХ үгүй байх; *ажил хийх гэсэн хүн үгүйдээд байна.*

ҮГҮЙЛҮҮЛЭХ үгүйлэхийн үйлдүүлэх хэв.

ҮГҮЙЛҮҮШТЭЙ үгүйлбэл зохистой.

ҮГҮЙЛЭГДЭХ үгүйлэхийн үйлдэгдэх хэв; байхгүй нь санагдах, мэдэгдэх; *хүү минь сургуульд явчихаад үгүйлэгдээд байна.*

ҮГҮЙЛЭХ 1. үгүй болсныг мэдэх; *маргааш нь хоёр тэмээгээ үгүйлэв;* 2. мөрөөдөх, санах, харамсах; *эхийгээ үгүйлэх.*

ҮГҮЙРҮҮЛЭХ үгүйрэхийн үйлдүүлэх хэв.

ҮГҮЙРЭЛ үгийрэл, хоосрол.

ҮГҮЙРЭХ үгийрэх, хоосрох, хоосон ядуу болох; *үгүйрэн хоосрох.*

ҮГҮЙТЭЙ үгийтэй, ядуу, хоосон, үгээгүү; **үгүйтэй хоосон** хорш..

ҮГҮЙТЭХ үгүйрэн хоосрох, үгүйтэй болох, үгийрэх.

ҮГҮҮ үгийгүү, үгээгүү.

ҮГҮҮ ЯА үгээгүү яа.

ҮГҮҮЛБЭР өгүүлбэр.

ҮГҮҮЛЛЭГ өгүүллэг.

ҮГҮҮЛЭГДЭХҮҮН өгүүлэгдэхүүн.

ҮГҮҮЛЭЛ өгүүлэл.

ҮГҮҮЛЭХ өгүүлэх.

ҮГҮҮЛЭХҮҮН өгүүлэхүүн.

ҮГЧЛҮҮЛЭХ үгчлэхийн үйлдүүлэх хэв.

ҮГЧЛЭХ үгийн дагуу үйлдэх; *үгчлэн унших; үгчлэн хөрвүүлэх;* **үгчлэн орчуулах** (утгыг дагахгүй, үг нэгбүрийг орчуулах); **үгчлэн цээжлэх** (утгыг үл анхаарах).

ҮГЭЭГҮҮ үгийгүү, хоосон, ядуу; **үгээгүү хоосон** х о р ш.; *орон бүхний үгээгүү нар нэгдэгтүн!* **үгээгүү доромж** (үгээгүү дорой).

ҮГЭЭР яр шархны илжирхий идээр ус.

ҮГЭЭРЛЭХ үгээртэй болох.

ҮГЭЭРТЭХ үгээр тогтох.

ҮГЭЭРШИХ үгээр идээртэй болох.

ҮД нар өдөр дунд болох, өдөр дүл; *үд болох; үд хүртэл хүлээх;* **жин үд** (яг үд); **бага үд** (жин үдийн урьдах үе); **үдийн амралт** (үдийн үед хийх амралт, аянчны үдийн буудал); **хонь үд оруулах** (хонийг үдийн үед авчран сааж, амруулах); **үдийн халуун** (өдөр дундын халуун); **үдийн хоол** (өдрийн хоол)

ҮДЛҮҮЛЭХ үдлэхийн үйлдүүлэх хэв.

ҮДЛЭГ зочныг явахад хийх ёс; **үдлэг өгөх** (явах зочинд бэлэг өгөх).

ҮДЛЭЛ үдлэх үйлийн нэр.

ҮДЛЭХ 1. аян замын хүний үдийн хирд буудаллан хооллож ундлан амрах; *аянчин жинчин үдлэх;* 2. ажил хөдөлмөртэй хүмүүсийн үдэд завсарлаж амсхийх; *албан хаагчид үдлэх;* 3. билчээрлэсэн хонь мал үдэд хотдоо ирэх; *хонио үдлэх.*

ҮДРҮҮЛЭХ үдрэхийн үйлдүүлэх хэв.

ҮДРЭХ үгдрэх.

ҮДҮН у р г а м а л иш өндөр, хээ сайхан, хөх навчтай нэг зүйл мод.

ҮДҮҮЛЭХ 1. үдэхийн үйлдүүлэх хэв; 2. үдэгдэх.

ҮДҮҮШТЭЙ үдвэл зохистой.

ҮДЭХ хүнийг явах, аялах, мордоход дагаж гаргаж өгөх; *зочдыг үдэх; үдэх ёслол.*

ҮДЭХ II юмыг утас, шөрвөс мэтээр холбож бэхлэх; *дэвтэр үдэх; хана үдэх;* **амаа үдэх** (үг үл хэлэх дуугай байх).

ҮДЭШ нар шингэхийн орчмоос цагаан гэгээ тасрах хүртлэх үе; *үдэш болох; өглөө үдэшгүй харуулдах; аав үдэш ирнэ; үдэш бүр давтлагатай;* **үдшийн бүрэнхий** (нар орж бүрэнхий болох); **үдшийн хоол** (оройн хоол).

ҮДЭШЛЭГ олон нийтээр үдшийн цагт зохиох зугаалга, цэнгэл; *сургууль дээр үдэшлэг болов; уран зохиолын үдэшлэг.*

ҮДЭЭР 1. юмыг үдэхэд хэрэглэх нарийн зүссэн шир; *хананы үдээр; аргийн үдээр; үдээрний шир;* 2. ш и л ж с э н хатуу арьстай, туранхай; *хөх үдээр болох.*

ҮДЭЭС 1. үдэж бэхэлсэн нь; *сайн үдээстэй хана;* **дансны үдээсэнд орох** (ямар нэгэн хэрэг гарч ирэхгүй болох, дарагдах); 2. үдэхэд хэрэглэх утас шөрвөс зэрэг; *юм үдэх үдээсний юм байна уу?*

ҮДЭЭСЛЭХ үдээстэй болгох, үдэх.

ҮЕ I 1. ургамлын ишний түгдэрхий газар; *хулсны үе; дэрсний үе; зэгсний үе;* 2. судал, зурвас, давхарга; *газрын хөрсний үе; хад чулууны үе;* 3. хүн, мал адгуусны ясны хөдөлгөө бүхий холбоо, залгаа, нугалмай; **үе гишүүн** х о р ш.; *гарын үе; өвдөгний үе; нурууны үе; сээрний үе; сүүлний ясны үе;* ☆ **үгийн үе** (үгийг хэлэхэд уушигнаас гарсан хийн түрэлт дагуу дуу тодорхой сонсдох хэсэг; *үеэр таслах*); **битүү үе** (гийгүүлэгчээр төгссөн үе); **задгай үе** (эгшгээр төгссөн үе); **үе мөчний өвчин** (мөч гишүүд янгинаж өвддөг бөгөөд цаашдаа зүрхэнд дамжин ордог нэг зүйл өвчин); 4. сур, шагаа, бөх зэрэг биеийн тамирчдын бүх оролцогчдын цэс; *анхдугаар үе; тавдугаар үе;* **үе шувтрах** (а. сур, шагаа харвахад данс самбарын харваачны мэргээс шувтрага хүртлэх хүмүүс дөрөв дөрвөн сумаа харваж төгсөх; б. бөх барилдахад оноо дансны аль нэгэн давааны бөхчүүд барилдаж дуусах); 5. цаг; **цаг үе** х о р ш.; *одоо үе; шинэ үе; дайны үе; хувьсгалын үе; тайван үе;* **манай үе** (эдүгээ цаг, *манай үеийн хүн);* **үеэ олсон** (цагаа олсон) **үе үе** (хааяа хааяа; *үе үе халуун болох; үе үе хүйтрэх; үе үе үхэтгэх; үе үе салхилах);* 6. цаг улирлын ойр зэргэлдээгээр баримтлан хуваасан хэм; *эртний үе; урьдын үе; хойч үе; одоо үе* 7. хүний төрөл уламжлалын зэрэг дэс; *өвгийн үе; эцгийн үе; хөвгүүний үе; ачийн үе;* **үе холдох** (ураг төрөл улирсаар хол болох, холын садан болох); **үе сунжрах** (үе холдох); **үе мултрах** (хүний насны ах дүү нь

арван хоёр наснаас хэтрэх); **нас үе** (арван насны доторхи хүмүүс); **үеийн хүн** (ойр насны хүн); **үеийн нөхөр** (нас ойр болоод итгэж нөхөрлөсөн хүн); **үе улирах** (төрөл удам уламжлах); **гэр үеийн бичмэл** (удам угсааны дараалсан бичиг); **үе залгах** (туранхалсан мал ногоо идэж тэнхрэх); **үе залгамжлах** (өвгөд хөгшдийг үр хүүхэд нь залгамжлах); **хойч үе** (хүүхэд багачууд); **үеийн үед** (үүрд). ᠲᠥᠷᠥᠰ ᠨ

ҮЕ II а м ь т а н далайд төрөх, бие тул шиг, зэвэг мэт бидэртэй, цайвар өнгийн загас; ☆ **цагаан үе** у р г а м а л (30—40 сантиметр өндөр, бутлаг ургамал, түрүү хэсэг зузаан навчтай, намар тийшээ шивээ гарна, шивээний үзүүр хурц бөгөөд хонь малын суга цавинд шивнэ, нялх байх үед нь мал иднэ).

ҮЕГҮЙ 1. үе байхгүй; *үзмийн мод нь үегүй дээ бөмбөр минь* (дуу); 2. биений нугарахдаа сайн, нугарамхай; *үегүй мэт нугарах.*

ᠲᠥᠷᠥᠰ ᠨ ᠲᠦᠭᠦᠢ

ҮЕЛҮҮЛЭХ үелэхийн үйлдүүлэх хэв. ᠲᠥᠷᠥᠰᠦᠭᠯᠡᠬᠦ

ҮЕЛЭХ 1. юмыг үе давхаргатай болгох *Монголын уран зохиолыг үелэх асуудлын тухай яриа;* 2. хөгжмийн аялгууг баахан намжуулж дахин үүсгэх. ᠲᠥᠷᠥᠭᠡᠬᠦ

ҮЕН а м ь т а н өмхий хүрнийн төрлийн, жижиг үслэг араатан амьтан, үсний өнгө цагаан бөгөөд сүүлийн үзүүр хар, үс их үнэтэй. ᠲᠥᠷᠦᠮᠡᠨ

ҮЕНЦЭР: үенцэр ах дүү хаяалид ах дүүгээс төрөгсөд; үенцэр хүү (хаяалид ах дүүгийн хүү). ᠲᠥᠷᠦᠯᠬᠡᠷ

ҮЕР 1. хур тундасны улмаас үлэмж нэмэгдэх ус; *усны үер татрах; үерийн ус;* 2. ширүүн бороо; *үер орох; үер буух; үер асгав.* ᠲᠥᠷ

ҮЕРЛҮҮЛЭХ үерлэхийн үйлдүүлэх хэв. ᠲᠥᠷᠯᠡᠭᠦᠯᠬᠦ

ҮЕРЛЭЛ үерлэх үйлийн нэр. ᠲᠥᠷᠯᠡᠯ

ҮЕРЛЭХ гол мөрний ус ихэд нэмэгдэх; *ус үерлэх; гол үерлэх.* ᠲᠥᠷᠯᠡᠬᠦ

ҮЕРХҮҮЛЭХ үерхэхийн үйлдүүлэх хэв. ᠲᠥᠷᠬᠡᠭᠦᠯᠬᠦ

ҮЕРХЭХ ойр настан, үеийн хүмүүсийн найралдах, бие биедээ дотно, найрсаг явах; *үерхдэг хүүхэн нь ирэв.* ᠲᠥᠷᠬᠡᠬᠦ

ҮЕС 1. үед, орчим, хир; *тэр үес; энэ үес; орчин үес;* 2. гишүүн, үе; **үес гишүүн** х о р ш.. ᠲᠥᠰ

ҮЕГ I 1. үе бий, үе давхрага бүхий; *нэг үеэ* 2. үе гишүү бүхий; *үет юм болохоор үеэрээ хөдөлж байна.* ᠲᠥᠭᠡ

ҮЕТ II ургамлын ишинд байдаг үе бүхий; **үет монгол** у р г а м а л (хэлбэр цагаан үетэй ойролцоо, бут шингэн, навч цөөн, шивээ богино бөгөөд бараан өнгөтэй, асга хадтай газар ургадаг ургамал, шивээ ургаж гүйцсэн хойно малд нөлөөтэй); **үет цагаан** у р г а м а л (усны хөвөө, тойром, сайрт ургах зэгс, дэрс мэт ургамал).

ҮЕТҮҮЛЭХ үетэхийн үйлдүүлэх хэв. ᠲᠥᠭᠡᠭᠦᠯᠬᠦ

ҮЕТЭЙ 1. үе бүхий; 2. шөрвөстэй, хөл сайтай, авд унахгүй; *үетэй залуу.* ᠲᠥᠷᠦ ᠨ ᠠᠪᠴ

ҮЕТЭН чацуу, ойролцоо настай; *үетэнгийн настай.* ᠲᠥᠭᠡᠭᠡᠨ

ҮЕТЭХ 1. үе гарч ургах, үетэй болох; 2. үетэй мэт харагдах. ᠲᠥᠭᠡᠭᠦᠯᠬᠦ

ҮЕЧЛЭЛ үелэх үйлийн нэр. ᠲᠥᠭᠡᠴᠯᠡᠯ

ҮЕЧЛЭХ үе болгож хуваах; *Монголын түүхийг үечлэх.* ᠲᠥᠭᠡᠴᠯᠡᠬᠦ

ҮЕЭЛ үеэлд. ᠲᠥᠭᠡᠯ

ҮЕЭЛД төрсөн ах дүүгийн хүүхэд; *үеэлд ах дүү;* **үеэлд бэр** (үеэлд хүүгийн гэргий); **үеэлд хүү** (төрсөн ах дүүгийн хүүхэд). ᠲᠥᠭᠡᠯᠳᠡ

ҮЖИЛ 1. үржрэх нь, илжрэн завдах нь; 2. хээр хатаж жил өнжин хөхөрсөн өвс; *үжил өвс.* ᠲᠥᠵᠢᠯ

ҮЖРҮҮЛЭХ үржрэхийн үйлдүүлэх хэв. ᠲᠥᠵᠢᠭᠦᠯᠬᠦ

ҮЖРЭХ эд юмны нар салхи, чийг мэтэд удтал байсаар өгрөх хэврэгших; *арьс үжрэх; даавуу үжрэх; мод үжрэх.* ᠲᠥᠵᠢᠭᠡᠬᠦ

ҮЖШИЛ үжших үйлийн нэр. ᠲᠥᠵᠢᠰᠬᠡᠯ

ҮЖШИХ үржрэх шинж орох; *үжшисэн даавуу.* ᠲᠥᠵᠢᠰᠬᠡᠬᠦ

ҮЗВЭР жүжиг, кино мэтийн үзэж сонирхох зүйл; *үзвэрийн газрууд.* ᠲᠥᠵᠥᠪᠡᠷ

ҮЗЛЭГ үзэх үйлийн нэр: 1. биеийг шинжлэх, үзэх, судлах нь; *эмчийн үзлэг;* 2. х у у ч и р с а н далд юмыг бэлэгдэх бэлэгдэл, төлөг. ᠲᠥᠵᠯᠡᠭ

ҮЗЛЭГЧ төлөгдөгч, бэлэгдэгч. ᠲᠥᠵᠯᠡᠭᠴᠢ

ҮЗМЭР музей, үзэсгэлэнд тавих юм; *музейд үзмэр цуглуулах; үзмэрийг судлах.* ᠲᠥᠵᠢᠮᠡᠷ

ҮЗМЭРЧ х у у ч и р с а н бэлэгч, ёрч. ᠲᠥᠵᠢᠮᠡᠷᠴᠢ

ҮЗҮҮЛЭГЧ 1. юмыг удирдан хянаж үзүүлэх хүн; 2. ямар нэг баримт юм үзүүлсэн этгээд; *үүнийг үзүүлэгч тэр бол...*

ҮЗҮҮЛЭЛ үзүүлэх үйлийн нэр.

ҮЗҮҮЛЭЛТ үзүүлэх юм; *тооны үзүүлэлт; өсөлтийг харуулсан үзүүлэлт.*

ҮЗҮҮЛЭН: үзүүлэн таниулах хичээл заах, ухуулга таниулга хийхэд хэрэглэх зураг, жишиг, амьтан ургамлын чихмэл, хатаамал зэрэг зүйлс; *үзүүлэн таниулах хэрэглэх; үзүүлэн таниулах хийх.*

ҮЗҮҮЛЭХ 1. үзэхийн үйлдүүлэх хэв; *эмчид үзүүлэх; тусламж үзүүлэх; сүр үзүүлэх; чадлаа үзүүлэх;* 2. үзэгдэх.

ҮЗҮҮР 1. нарийн гонзгор юмны шовх, нарийн тал; *харандааны үзүүр; хурууны үзүүр; хэлний үзүүр; уулын үзүүр; тэвнийн үзүүр; өргөсний үзүүр;* **үзүүр гаргах** (үзүүр бий болгох, үзүүрлэх); 2. уурганы нарийн талд залгах савaa; *уурганы үзүүр;* **үзүүр татах** (уурганы үзүүрт нарийн мод залгах); 3. ш и л ж с э н бөх барилдахад үлдэх эцсийн хоёр бөх; *үзүүрийн бөх; үзүүрт үлдэх;* **үзүүр булаалдах** (бөх барилдахад эцэст үлдсэн хоёр бөхийн барилдах; *хэн гэгч бөх үзүүр булаацалдав?*); 4. ш и л ж с э н хязгаар, туйл; *үзүүр хязгааргүй их; сэтгэлийн үзүүр.*

ҮЗҮҮРГҮЙ 1. үзүүр байхгүй; *үзүүргүй харандаа;* 2. ш и л ж с э н хязгаар дуусгаваргүй.

ҮЗҮҮРЛҮҮЛЭХ 1. үзүүрлэхийн үйлдүүлэх **хэв**; 2. үзүүрлэгдэх; *нүд үзүүрлүүлэх.*

ҮЗҮҮРЛЭГДЭХ үзүүрлэхийн үйлдэгдэх хэв.

ҮЗҮҮРЛЭХ 1. үзүүр гаргах; *шөвөг үзүүрлэх;* 2. уургад үзүүр татах; *уурга үзүүрлэх;* 3. **барилдаж** түрүүлэх; 4. ш и л ж с э н гадуурхан үзэх; **нүд үзүүрлэх** (гадуурхах, хажигдах).

ҮЗҮҮРСЭГ уртын ноосыг хяргасан хонины үс нь ургаж, хайчилсны ором арилсан арьс, зүн хяргаснаас хойш намар алсан хонины арьс; *үзүүрсэг дээл.*

ҮЗҮҮРСЭГЛЭХ уртын ноосыг хяргасан хонины үс ургаж хайчны ором арилах.

ҮЗҮҮРТ үзүүр бий; *нэгэн үзүүрт сэтгэлээр хичнээн зүтгэв.*

ҮЗҮҮРТЭЙ 1. үзүүр бүхий; 2. дуусвар бүхий.

ҮЗҮҮРХЭХ танхилзах, оморхох, омогтой зан гаргах.

ҮЗҮҮШТЭЙ үзмээр, үзвэл зохих; *үзүүштэй жүжиг.*

ҮЗШИЛ 1. үзэгдэх бололцоо; *үзшил сайтай;* 2. үзэгдэх шинж байдал.

ҮЗЭГ I юм бичих, зурахад хэрэглэх, салаа үзүүр бүхий хавтгай, хумбагар зүйл; *төмөр үзэг; хулсан үзгээр бичсэн ном.*

ҮЗЭГ II үсэг.

ҮЗЭГДҮҮЛЭХ үзэгдэхийн үйлдүүлэх хэв.

ҮЗЭГДЭЛ 1. үзэгдэх зүйл, мөн чанар нь, харагдах зүйл; *байгалийн үзэгдэл; ердийн үзэгдэл; хоосон үзэгдэл;* 2. жүжгийн гарах хүмүүсийн бүрэлдэхүүн үл өөрчлөгдөх бүлэг.

ҮЗЭГДЭХ үзэхийн үйлдэгдэх хэв; **үзэгдэх сар** (нярайлах сар).

ҮЗЭГДЭШГҮЙ үзэгдэхийн аргагүй, үзэхийн аргагүй, үзэхэд бэрхтэй, жигшүүртэй; *үзэгдэшгүй сайхан; үзэгдэшгүй муухай; үзэгдэшгүй ховор.*

ҮЗЭГЛЭХ үсэглэх; *номоо үзэглэж унш; сайн харж үзэглэхгүй юу.*

ҮЗЭГЧ үзэж байгаа этгээд; *жүжиг үзэгч олон цөм сайшаан магтаж байв; би үзэгчийн хувьд.*

ҮЗЭЛ санааны шийдвэр, санал, бодол; *зөв үзэл; буруу үзэл;* **үзэл суртал** (аливаа нэгэн нийгмийн анги, нийгэм-улс төрийн байгуулал чиглэлийг илэрхийлж хамгаалсан онол); **үндэсний үзэл** (үндэстнийг хооронд нь турхиран дайсагнуулах, үндэстнүүдийг дарлан мөлжигч бурзуй нарын ашиг сонирхлыг дэмжиж өөрийн үндэстнийг бусдаас илүүд үзэх бурзуйлиг харгис үзэл болон улс төрийн бодлого); **дэвшилт үзэл** (хөгжлийн явцад улам улмаар сайжирч дэвших үзэл); **харгис үзэл** (хувьсгалт хөдөлгөөн, дэвшилт үзэл санааг эсэргүүцэн, дарлагч ангийн эрх ашиг, улс төрийн бодлогыг баримталсан үзэл).

ҮЗЭЛДЭХ 1. үзэхийн үйлдэлдэх хэв; 2. ш и л ж с э н хүч тэмцэлдэх, үзэлцэх, ноцолдох.

ҮЗЭЛТЭЙ үзэл бүхий; *марксист үзэлтэй хүн; эх оронч үзэлтэй; идеалист үзэлтэй.*

ҮЗЭЛТЭН ямар нэгэн үзэл бүхий этгээд; *ардчилсан үзэлтэн; шударга үзэлтэн; харгис үзэлтэн; бөөрөнхий үзэлтэн.*

ҮЗЭЛЦЭХ 1. үзэхийн үйлдэлцэх хэв; 2. ш и л ж с э н тэмцэлдэх, маргалдах, ноцолдох; *хүчээ үзэлцэх.*

ҮЗЭЛЧ үзлэгч.

ҮЗЭМ усан үзмийн хатаамал; *усан үзмийн чихэр;* **усан үзэм** у р г а м а л (а. жимсгэнэ бүхий нэг зүйл сөөглөг ургамал; б. мөн сөөглөг ургамлаас ургах шүүслэг, сайхан амттай жимсгэнэ).

ҮЗЭМЖ I үзэгдэх төрх байдал; *үзэмж муутай; үзэмж сайтай.*

ҮЗЭМЖ II ямар гэж үзэх санал, бодол, таалал; *үзэмжээр болох; дургын үзэмж мэдэнэ.*

ҮЗЭМЖГҮЙ үзэмж муутай, муухай үзэгдэх; *үзэмжгүй явдал болов.*

ҮЗЭМЖИТ үзэмж буй, гоё; *үзэмжит сайхан нутаг.*

ҮЗЭМЖТЭЙ тааламжтай, аятай.

ҮЗЭМЧ үзэм таригч.

ҮЗЭМЧИН Өвөр монголын нэгэн аймаг.

ҮЗЭСГЭЛЭН 1. гоо, сайхан; *үзэсгэлэн төгөлдөр охин;* 2. нийтэд үзүүлж сонирхуулахаар тусгай тавьсан зүйлс; *Зөвлөлт Улсын хөдөө аж ахуйн үзэсгэлэн; ардын үзэсгэлэн.*

ҮЗЭСГЭЛЭНТ үзэсгэлэнтэй; *үзэсгэлэнт сайхан байгаль.*

ҮЗЭСГЭЛЭНТЭЙ үзэсгэлэн бүхий, үзэхэд хавтай, сайхан; *үзэсгэлэнтэй сайхан цэцэрлэг.*

ҮЗЭХ 1. харах; **үзэх харах** х о р ш.; *зураг үзэх; кино үзэх; толинд үзэх;* **нүдээрээ үзэх** (өөрөө дэргэд нь байж харах); 2. сурах; судлах; *гадаад хэл үзэх;* **ном үзэх** (ном сурах, харах); 3. өвчин бий үгүйг шинжлэх; *өвчтөний биеийг үзэх; ханиад хүрсэн хүнийг үзээд эм өгөв;* 4. бодох, бодлого агуулах, тооцох; *энэ явдлыг чиний буруу гэж үзэж байна; би энэ явдлыг зөв гэж үзэж байна;* 5. х у у ч и р с а н мэрэг төлөг тавих; *төлөг үзэх; дал тавьж үзэх;* 6. эдлэх, амсах; *зовлон үзэх; гачигдал үзэх; өнчрөл үзэх; жаргал үзэх;* 7. турших, сорих; *янзы нь үзэх; юу ч болсон яваад л үзэх хэрэгтэй; хүчээ үзэх;* 8. амтлах; *амты нь үзэх; давсы нь үзэх;* 9. мэрийх, чармайх; *бушуу харихыг хичээж үз; биеэ барьж үз; нөгөө шүлгээ сайн тогтоож үзээрэй;* 10. хашир болох; *их юм үзсэн хүн; үхэхээс бусдыг үзсэн толгой;* **юм үзэж нүд тайлах** (хол ойр явж хашир болох; ☆ **үзэх харах** (тэтгэх, хайхрах, асрамжлах; *үзэх харах хүнгүй).*

ҮЗЭШГҮЙ үзэхийн аргагүй, үзэхэд муухай, жигшүүртэй; *үзэшгүй муухай.*

ҮЗЭЭГҮЙ 1. үл үзсэн, эс үзсэн, *үзээдүй; үзээгүй хараагүй юм;* 2. тохиолдоогүй, дайралдаагүй; *үзээгүй юмаа үзэж, үхэр цамаа харайх* з у й р.

ҮЗЭЭС I гайхах дуу алдахад өгүүлэх аялга; үг; *үзээс хэдийнээ дэргэд ирж зогсжээ.*

ҮЗЭЭС II язгуурын, угийн, үзэхэд л; *намайг үзээс ийм байсан билээ; үзээс тийм байсан гэж хүнээс сонссон.*

ҮЙ тооны маш үлэмжийн их; *үй олон; үй түмэн хүн; арааран дүүрэн ай түмэн адуутай, өврөөрөө дүүрэн үй түмэн адуутай* (үлгэр).

ҮЙЛ 1. хийж явуулах хэрэг явдал, **үйлдвэр; үйл үйлдвэр, үйл хэрэг, үйл ажиллагаа** х о р ш.; *зохиолчийн амьдрал ба үйл ажиллагаа; сайн үйл; муу үйл; гэмт үйл; зөв үйл;* **үйл хийх** үйлдвэр хийх); **үйл үг** (юмны үйл буюу байдлыг зааж хэлсэн үг); 2. оёх, урлах зүйл; **үйл их хийж байна уу?** (юм их оёж байна уу?); **үйл сайтай** (оёж урлахдаа сайн); **үйл муутай** (оёж урлахдаа муу); **үйл бүт** (аж үйлдвэр хийж байгаа хүнд ерөөж хэлэх үг); 3. зовлон; **үйл зовлон, үйл там** х о р ш.; *үршиг үйлээ эдлэх; үйл үзэх; үйлий нь үзүүлэх;* **үйл тамаа цайх** (ихэд зовлон эдлэх, амсах); **үйлийн үр** (үйлдсэн муу явдлын уршиг нөлөө, үр боловсрол); ☆ **үйл нь ирэх** (үхэл нь ирэх; *үйл нь ирсэн хулгана, муурын бөөрийг маажих)* з ү й р.

ҮЙЛГЭХ үйхийн үйлдүүлэх хэв.

ҮЙЛДВЭР 1. ардын аж ахуйн нэг салбар болох бөгөөд түүхий эд, ашигт малтмалыг боловсруулах газар; *нэхмэлийн үйлдвэр; химийн үйлдвэр; гутлын үйлдвэр; үйлдвэрийн ажилчин;* **боловсруулах үйлдвэр** (нэхмэл, арьс шир, цаас, хими гэх мэтчилэнгийн үйлдвэрийн газар); **малтах үйлдвэр** (уул уурхай зэрэг үйлдвэрийн газар); **хүнд үйлдвэр** (машин, үйлдвэрийн тоног хэрэглэл, илч хүчин, түлш үйлдвэрлэх газар); **хөнгөн үйлдвэр** (хэрэгцээний юм үйлдвэрлэх газар); **гар үйлдвэр** (аливаа юмыг фабрикийн аргаар биш, гараар үйлдвэрлэх газар); **хүнсний үйлдвэр** (идэш, уушны зүйлийг үйлдвэрлэх газар); **үйлдвэрийн бүтээгдэхүүн** (үйлдвэрлэн гаргаж байгаа бүх юм); **үйлдвэрийн орон** (үйлдвэр голлон хөгжүүлж байгаа орон; *хөдөө аж ахуй, үйлдвэрийн орноос үйлдвэр, хөдөө аж ахуйн орон*

болох); 2. х у у ч и р с а н үйлдэн хийж байгаа юм. ажил.

ҮЙЛДВЭРЖИХ үйлдвэртэй болох.

ҮЙЛДВЭРЖҮҮЛЭХ үйлдвэржихийн үйлдүүлэх хэв.

ҮЙЛДВЭРЛҮҮЛЭХ үйлдвэрлэхийн үйлдүүлэх хэв.

ҮЙЛДВЭРЛЭЛ 1. үйлдвэрлэх үйлийн нэр, үйлдвэрлэх үйлийн явц; 2. материал баялгийг бий болгох нийгмийн процесс бөгөөд үйлдвэрлэх хүчин үйлдвэрлэлийн харьцаа хоёрыг хамарна: **үйлдвэрлэлийн харьцаа** (үйлдвэрлэлийн процесст хүмүүсийн бие биетэйгээ харьцах харьцаа).

ҮЙЛДВЭРЛЭХ боловсруулах, хийх, ажиллах; *үйлдвэрлэн гаргах бараа;* **үйлдвэрлэх хүчин** (үйлдвэрлэлийн багаж, ажиллах хүчний цогц).

ҮЙЛДВЭРЧИН биеийн хүчин үнэлж амьдрах хүн; **үйлдвэрчний эвлэл** (үйлдвэрийн ямар нэгэн салаа мөчрийн ажилтны байгууллага; *үйлдвэрчний эвлэлийн гишүүн; үйлдвэрчний эвлэлийн төв зөвлөл*).

ҮЙЛДГЭХ үйлдүүлэх; **үйлдгэх ʻял** (ажил хийлгэх ял).

ҮЙЛДҮҮЛЭХ үйлдэхийн үйлдүүлэх хэв.

ҮЙЛДЭЛ харилцан үйлдэх үйлийн нэр.

ҮЙЛДЭХ хийх, бүтээх; *чи энд юу үйлдэж байна вэ? үйлдсэн буруу хэргийг гэмшив;* **үйлдэх орон** (ажил хийх орон); **үйлдэхийн тийн ялгал** (монгол хэлний зургадугаар тийн ялгал).

ҮЙЛДЭХҮҮН бүтээгдэхүүн; *үйлдэхүүний яс чанарыг сайжруулах; үйлдэхүүний өөрийн өртгийг хямдруулах.*

ҮЙЛЗЭХ 1. үе үе хөдлөх, хоролзон хөдлөх, салхины хүүс хүүс ширүүдэх; *салхи зүг зүгээс хоролзон үйлзэж байв; далайн ус давлан үйлзэх; галын дөл сажин үйлзэх;* 2. ш и л ж с э н сэтгэл тогтворгүй болох; *сэтгэл үйлзэх; үйлзсэн зантай хүн.*

ҮЙЛС 1. зорьсон санасан үйл явдал; *үйлс бүтэх;* 2. золбоо, хий морь, бүтэмж; **үйлс нь харлах** (хий морь, цог заль нь доройтох).

ҮЙЛСГҮЙ 1. санасан зорьсон үйл явдал бүтэмжгүй, урагш муутайгий нь; *ямар үйлсгүй өдөр вэ!* 2. золбоо, хий моригүй.

ҮЙЛСТЭЙ 1. санасан зорьсон үйл явдал бүтэмжтэй; *энэ жил их л үйлстэй байлаа;* 2. золбоотой, хий морьтой.

ҮЙЛТ үйл бүхий; **үйлт нэр** (тийн ялгалаар ялгагдах үйл үг).

ҮЙЛТЭЙ үйл бүхий, зовлонтой.

ҮЙЛЧ (ИН) юм оёхдоо чадамгай хүн, хувцас хунар оёх мэрэгшилтэй хүн.

ҮЙЛЧИЛГЭЭ алив хэрэгцээг хангахын тулд ажиллах ажиллагаа; *үйлчилгээ сайтай; үйлчилгээ муутай.*

ҮЙЛЧЛҮҮЛЭХ 1. үйлчлэхийн үйлдүүлэх хэв; 2. үйлчлэгдэх.

ҮЙЛЧЛЭГДЭХ үйлчлэхийн үйлдэгдэх хэв.

ҮЙЛЧЛЭГЧ үйлчлэх хүн; *төлөөлөгчдийг үйлчлэгч.*

ҮЙЛЧЛЭЛ үйлчлэх нь; *үйлчлэлийн байдал.*

ҮЙЛЧЛЭХ 1. ахас ихсийг хичээнгүйлэн сувилах, тэтгэх; *зочдод үйлчлэх; эцэг эхдээ үйлчлэх;* 2. шудрага зүтгэх; *эх орондоо үнэнч шударга үйлчлэх.*

ҮЙМҮҮЛЭХ 1. үймэхийн үйлдүүлэх хэв; 2. ажил хийлгэхгүй, зүгээр байлгахгүй бужигнуулах, саад хийх; *хүүхдүүд ээ, битгий үймүүл, томоотой байцгаа!*

ҮЙМЦҮҮЛЭХ үймцэхийн үйлдүүлэх хэв.

ҮЙМЦЭХ 1. үймэх, үйлзэх; 2. салхи бороо ширүүн хөдлөх; *салхи үймцэх.*

ҮЙМЭЛДЭХ үймэхийн үйлдэлдэх хэв.

ҮЙМЭЛЦЭХ үймцэхийн үйлдэлцэх хэв.

ҮЙМЭХ 1. бужигнах, эмх замбараагүй болох, холилдох; *үймэх бужигнах; шинэ жил болж олон хүн үймж байв;* 2. ш и л ж с э н оюун ухааны онч, сэтгэл санаа тогтворгүй болох; *дотор үймэх; сэтгэл үймэх.*

ҮЙМЭЭН 1. үймсэн нь; **үймээн бужигнаан, үймээн шуугиан** х о р ш.; 2. дайн, дажин, самуун; **үймээн самуун** х о р ш.; **хөл үймээн** (дайн, дажин).

ҮЙМЭЭНЧ 1. үймээнд дуртай; 2. үймээн самуунд оролцогч.

ҮЙРМЭГ үйрч жижгэрсэн юм; *үйрмэг эвэгий; үйрмэг ааруул; үйрмэг шороо.*

ҮЙРҮҮЛЭХ үйрэхийн үйлдүүлэх хэв, үйрмэг болгох.

ҮЙРЭМ үйрмээр, үйрмэг.

ҮЙРЭХ няцарч, бацарч жижиг үйрэм болох; *үйрч унах; боов үйрэх; талх үйрэх.*

ҮЙС (ЭН) хус модны дурс; *үйсээр гал ноцоох; үйсэн хувин;* **үйсэн түүс** (үйсээр хийсэн сав).

ҮЙСЛЭХ 1. үйсээр бүрэх, хулдах; *хутганы хуй үйслэх;* 2. модны үйсийг хуулах; *мод үйслэх.*

ҮЙТЭН: үйтэн хуар цулгуй өнгөнд хээ товойлгож үйлдсэн нэг зүйл торго; *үйтэн хуар дээл.*

ҮЙХ I хоолны мах, гурил зэргийг тогоон дахь ус, тосонд хийх; *тогоонд мах үйх; цай үйх.*

ҮЙХ II олноороо гүн усанд орж үхэх; *дайсны цэргүүд Орхонд үйж үхэв гэж хэлэлцдэг.*

ҮЙЧҮҮР зүйл зүйлийн амьтны зурагт их бага үнэ зохион шоо орхиж, туссан тоогоор хуваан авч илүү тоотой нь хожих тоглоом; *үйчүүр наадах.*

ҮЛ үйлт нэр, нөхцөл үйл үг, цаг заах үгийн өмнө хэрэглэдэг үгүйсгэх үг; *үл чадах ажээ; үл болох; үл олдох зүйл; үл барагдах юм; бичиг үл мэдэх явдлыг манай оронд бүрмөсөн арилгав; үл таних хүн; орж үл болно!* **үл барам** (үүгээр эс дуусам; *архи уухаар үл барам, бусдад агсам тавьж зодоон гаргасан байна*); **үл хөдлөх хөрөнгө** (эдлэл газар, барилга сууц зэрэг хөрөнгө); **үл мэдэг** (ялимгүй; *үл мэдэг их; үл мэдэг бага*); **үл тааламжлах** (таалахгүй, тоомсорлохгүй).

ҮЛБИЙЛГЭХ үлбийхийн үйлдүүлэх хэв, үлбэгэр болгох.

ҮЛБИЙХ үлбэгэр болох; *амт нь үлбийх; эрч нь үлбийх.*

ҮЛБЭГНҮҮЛЭХ үлбэгнэхийн үйлдүүлэх хэв.

ҮЛБЭГНЭХ үлбэгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ҮЛБЭГЭР амт муутай, сул, үлхгэр; *үлбэгэр амттай архи; үлбэгэр эрчтэй дээс; үлбэгэр биетэй амьтан; үлбэгэр ястай эд.*

ҮЛБЭЛЗҮҮЛЭХ үлбэлзэхийн үйлдүүлэх хэв.

ҮЛБЭЛЗЭХ үлбэгэр юмны байн байн хөдлөх.

ҮЛБЭН хэлхэж чимэг болгон хэрэглэх өнгөтэй өнгөгүй өчүүхэн бөөрөнхий шилүүд; *үлбэн хэлхэж зүүх.*

ҮЛБЭР үлдвэр; *үлбэр хоол.*

ҮЛГҮҮЛЭХ үлгэхийн үйлдүүлэх хэв

ҮЛГЭН: үлгэн салган ухаан мэдрэл тамир тэнхээ нь муудсан байдалтай.

ҮЛГЭР I ардын аман зохиолын нэгэн төрөл болох бөгөөд гол төлөв ид шидтэй хүн амьтан, мангас тэргүүтэн гардаг хүүрнэх зохиол; **үлгэр домог** х о р ш.; *үлгэрт гардаг жаргалыг ч үнэн хэрэг дээр эдэлж, бага их бүгдээрээ, баярын магнай тэнийж байна; үлгэр хэлэх; явган үлгэр;* **бадарчны үлгэр** (Монголчуудын хэлэлцдэг хошин үлгэр); **ёгт үлгэр** (далд утгатай богино зохиол, ихэнхийн төгсгөлд сургаалын чанартай дүгнэлт байдаг); **үлгэрийн баатар** үлгэрт гардаг голлогч этгээд).

ҮЛГЭР II 1. загвар, маяг, хувцас тэргүүтний дууриалган хийх хэлбэрийн жишээ; *малгайн үлгэр;* **үлгэр авах** (аливаа юмыг үйлдэх хийхийн зэрэгт бусад юмыг жишээ болгож дууриах); **үлгэр жишээ** (аливаа дууриал буюу цээрлэл болгохоор үзүүлэх таниулах зүйл); 2. аливаа юманд адилтгах дүрэм жишээ болгох зүйл; *сайнаас үлгэр авах, сааraас жигшин зайлах; үлгэр жишээ болох;* **үлгэр дүр** (а. үлгэр дүрэм ба хүний аж явдлын бахархан хараалагдах хувь; б. хүн амьтан ба эд бодис зэргийн хэлбэр янз).

ҮЛГЭРЛҮҮЛЭХ үлгэрлэхийн үйлдүүлэх хэв.

ҮЛГЭРЛЭЛ үлгэрлэсэн нь.

ҮЛГЭРЛЭХ үлгэр болгох, зүйр болгох, жишээ болгох; *үлгэрлэж хэлэх.*

ҮЛГЭРЛЭШГҮЙ үлгэрлэж зүйрлэшгүй.

ҮЛГЭРЧ (ИН) үлгэр хэлдэг хүн; *үлгэрч туульч нарын тухай ярих.*

ҮЛГЭХ зогсолтгүй шунаж хөхөх; *хөхөө үргэлж үлгэж байх муу зантай болжээ.*

ҮЛДВЭР зарж хэрэглээд илүүдэн хоцорсон зүйл, үлдэгдэл.

ҮЛДҮҮР үргээж зайлуулах хэрэгсэл; *ялааны үлдүүр.*

ҮЛДЭГДЭЛ үлдсэн юм; **үлдэгдэл шавхруу** х о р ш.; *үлдэгдэл бараа; үлдэгдэл хоол; хуушин нийгмийн үлдэгдэл.*

ҮЛДЭГДЭХ 1. үлдэхийн үйлдэгдэх хэв; 2. үлэх, хоцрох.

ҮЛДЭЛ үлсэн нь, үлдсэн юм, үлдэгдэл; **үлдэл хэтрэл** хорш..

ҮЛДЭХ I 1. хэрэглэсэн юмнаас, хэрэглэгдэлгүй илүүдэж гарах; *үлдсэн хэдэн хайрцаг тамхи;* 2. хоцрох, үлэх; *бусад нь явж, нэг нь гэртээ үлдэв.*

ҮЛДЭХ II хөөх, зайлуулах; *үлдэн хөөх; үлдэн зайлуулах.*

ҮЛДЭЦ үлдсэн юм; *үлдэцтэй сайн юм бүтээж өгөв; үлдэц муутай.*

ҮЛДЭЭХ үлдэхэд хүрүүлэх, үлдүүлэх.

ҮЛЖГЭР үлбэгэр, сул дорой, гулжгар

ҮЛЖИГНЭХ үлжгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ҮЛЖИЙЛГЭХ үлжийхийн үйлдүүлэх хэв.

ҮЛЖИЙХ үлжгэр болох.

ҮЛЖИЛЗЭХ үлжгэр юмны байн байн хөдлөх.

ҮЛИЙ газар доогуур оготно, хулганын онгичиж сэндийлсэн газар; *үлийтэй газар; үлийд ойчих.*

ҮЛИЙРЭХ үлий болох.

ҮЛИЙТЭХ үлийтэй болох.

ҮЛИЙШИХ үлийтэй болох шинж орох.

ҮЛТ хэмх, зад, бут; *үлт чанах;* **үлт цохих** (үлтэртэл жанчих).

ҮЛТЛҮҮЛЭХ үлтлэхийн үйлдүүлэх хэв.

ҮЛТЛЭХ 1. үлтрэхийн үйлдүүлэх хэв, үлтрүүлэх; 2. шилжсэн бусдыг халдан зовоож зарцлах.

ҮЛТРҮҮЛЭХ үлтрэхийн үйлдүүлэх хэв.

ҮЛТРЭХ 1. элэгдэх, муудах, хэмхрэх, эвдрэх; 2. урагдаж тамтаггүй болох; 3. шилжсэн зовж зүдрэх, дарлагдан зарцлагдах.

ҮЛТЧИХ байн байн үлтлэх.

ҮЛТЭС үлтэрсэн юм, хэмхэрч унгарил болсон юм; *үлтэс ч алга!*

ҮЛТЭСРҮҮЛЭХ үлтэсрэхийн үйлдүүлэх хэв.

ҮЛТЭСРЭХ үлтэс болох, үлтрэх.

ҮЛҮҮ илүү.

ҮЛҮҮДҮҮЛЭХ илүүдүүлэх.

ҮЛҮҮДЭХ илүүдэх.

ҮЛҮҮР багцаалан хэмжих хэрэглэл.

ҮЛҮҮХЭН арай үлүү, баахан үлүү, илүүхэн.

ҮЛҮҮЧЛЭХ илүүчлэх.

ҮЛҮҮЧЛҮҮЛЭХ илүүчлүүлэх.

ҮЛХГЭР 1. уяа баглаа сул, муу; 2. шилжсэн амт муутай, сул; *үлхгэр гарсан архи;* 3. шилжсэн бие дорой, тамиргүй; 4. юмны эрч үлбэгэр сул; *үлхгэр дээс.*

ҮЛХИЙ уруулын хөрс яршиж эдгэрэхгүй улцайх гэм; *үлхий болох; үлхий амтай.*

ҮЛХИЙЛГЭХ үлхийхийн үйлдүүлэх хэв.

ҮЛХИЙРЭХ үлхий болох.

ҮЛХИЙХ үлхгэр болох.

ҮЛХЭГНҮҮЛЭХ үлхэгнэхийн үйлдүүлэх хэв.

ҮЛХЭГНЭХ үлхгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ҮЛХЭЛЗҮҮЛЭХ үлхэлзэхийн үйлдүүлэх хэв.

ҮЛХЭЛЗЭХ үлхгэр юмны байн байн хөдлөх.

ҮЛШГҮЙ 1. хэмжиж багцаалж болшгүй; 2. үлгэрлэж жишээлж болшгүй.

ҮЛЭГ I үнэч.

ҮЛЭГ II ухаан мэдрэл муутай, гөлрөө байдалтай; *үлэг өвчтэй.*

ҮЛЭГДЭЛ үлдэгдэл.

ҮЛЭМЖ их, маш, олон, онц; *үлэмж хүчтэй; үлэмж ухаантан; үлэмж хэмжээний цэрэг; үлэмж олон хонь; үлэмж сайн.*

ҮЛЭМЖИД үлэмж.

ҮЛЭМЖДҮҮЛЭХ үлэмждэхийн үйлдүүлэх хэв.

ҮЛЭМЖДЭХ хэтэрхий үлэмж болох, олдох, ихдэх; *тоо нь үлэмждэх; хэмжээ үлэмждэх.*

ҮЛЭМЖЛЭХ үлэмж болгох, маш их болгох.

ҮЛЭМЖХЭН үлэмж, маш үлэмж; *үлэмжхэн мал билчиж байв; үлэмжхэн үнэ хүрчээ; үлэмжхэн бараа буув.*

ҮЛЭХ I үлдэх, хоцрох.

ҮЛЭХ II багцаалж хэмжих.

ҮЛЭЭВЭР үлээдэг юм, үлээгүүр.

ҮЛЭЭГДЭХ үлээхийн үйлдэгдэх хэв.

ҮЛЭЭГҮҮР 1. үлээж хэрэглэх зэвсэг; 2. гал үлээхэд хэрэглэх нарийн гуурс; *галын үлээгүүр;* 3. үлээж дуугаргах хөгжмийн зэвсэг, үлээвэр; *үлээгүүр хөгжим.*

ҮЛЭЭГҮҮРЧ үлээгүүр хөгжмөөр хөгжимдөх хүн.

ҮЛЭЭЛГЭХ 1. үлээхийн үйлдүүлэх хэв; 2. үлээгдэх.

ҮЛЭЭЛЭГ 1. үлээх үйл; 2. үлээж дуугаргах хөгжмийн зэвсэг.

ҮЛЭЭХ I 1. амаар хийг хүчтэй цоргиулан гаргах; *хөгжим үлээх; гал үлээх; гүзээ үлээх; тоосы нь үлээх;* 2. салхи хийн тусах үүгэх; *урьхан салхи үлээх; цонхноос үлээж байна.*

ҮЛЭЭХ II үлэх I-ийн үйлдүүлэх хэв, үлдээх, хоцроох.

ҮМБҮҮ бяцхан хүүхэд, үхрийг нэрлэх үг.

ҮМГЭР өмгөр.

ҮМИЙЛГЭХ үмийхийн үйлдүүлэх хэв.

ҮМИЙХ үмгэр болох; *ам нь үмийх; арьс шир үмийтэл хатах.*

ҮМРҮҮЛ савны ам амсрыг хуниаслах оосор, зарим нутагт гудруул ч гэдэг.

ҮМРҮҮЛЭХ хол хол шидэх, муухай оёх.

ҮМТЭХ загасны, усан дотор үлээж хөөс гаргах.

ҮМХИЙ өмхий.

ҮМХИЙРҮҮЛЭХ үмхийрэхийн үйлдүүлэх хэв.

ҮМХИЙРЭХ өмхийрөх.

ҮМХ 1. аман дотор дүүрэх хэмжээтэй юм; *үмх хоол; үмх будаа;* 2. шилжсэн өчүүхэн, бага, чамлах санаа.

ҮМХЛЭХ байн байн үмхэх.

ҮМХҮҮЛЭХ үмхэхийн үйлдүүлэх хэв.

ҮМХЭХ 1. амандаа нэгмөсөн хийх, аманд зуух; *ганц үмхэж орхив; нохой үмхэх;* 2. бахь мэтийн хазуурын хазах; **үмхэх хазах** хорш..

ҮНГҮҮЛЭХ 1. үнгэхийн үйлдүүлэх хэв; 2. үнгэгдэх.

ҮНГЭГДЭХ үнгэхийн үйлдэгдэх хэв.

ҮНГЭЛДЭХ үнгэхийн үйлдэлдэх хэв.

ҮНГЭХ 1. үйрүүлэх, няцлах, үйрмэг болгох; *аргал үнгэх; тамхи үнгэх;* 2. шилжсэн юмыг хайр гамгүй эдэлж муухай болгох; *хувцсаа үнгэх;* 3. шилжсэн бусдыг нухчих, ноолох; *нохой, хүүхэд үнгэх; чи битгий дүүгээ үнгээд бай.*

ҮНДСЭРХҮҮ үндэслэг, нилээд үндэстэй.

ҮНДСЭРХЭГ 1. үндэслэг; 2. үндсээ баримтлагч; *үндсэрхэг үзлийн илрэл гаргах.*

ҮНДСЭРХЭХ өөрийн үндэстнийг бусад үндэстнээс давуутай гэж үзэх; *үндсэрхэх үзэл байж болохгүй.*

ҮНДЭС (ҮНДСЭН) *1.* ургамлын шорооны дотор байж тогтоцтой болгон, ус чийг ба тэжээлийг залгуулах хэсэг; *модны үндэс; үндсээр нь булгалах;* **үндсэн аяга** (модны үндсийг ухаж хийсэн аяга); 2. эх, үүсгэл, суурь, иш бат; *үндсээр нь устгах; үндсээр нь шинэчлэх; ямар эх үндэстэй болохыг хянах; үндэс болох; үндэс нь юу вэ? марксизм-ленинизмийн үндэс; онолын үндэс;* **үндсэн суурь** (а. аливаа нэгэн нийлүүллийн үндсэн хөл; б. хувилахуй ухааны урвалд огт хөдлөх хувьсахгүй нэг нийлүүллээс нөгөө нийлүүлэлд уламжлагдах бүлэг хумхи; в. аливаа үйл ажлын үүсгэл болох бааз хөрөнгө); **үгийн үндэс** (үгийн үндсэн утга заах хэсэг буюу үг зүйн ёсоор янз бүрийн дагавар залган цаашаа хувилгаж болох хэсэг); 3. гол, ерөнхий; **үндсэн өнгө** (цагаан шар улаан хөх хар энэ таван өнгө); **үндсэн хөрөнгө** (үйлдвэрлэлийн хэрэгсэлд зориулсан хөрөнгө); **үндсэн хууль** (улсын тулгуур хууль); **үндэсний үер** (газар гэсэхэд ус нь дээш нэвчиж мөрөн голын ус нэмэгдэн үерлэх үер); **үндсэндээ** (үнэндээ, чухамдаа, ерөнхийдөө; *үндсэндээ дүүгий нь зөв байв*); 4. үндэстэн, үндэстний; *үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн; монгол үндэсний бүжиг; үндэсний хувцас үндэсний үзэл; үндэсний асуудал; үндэс-*

ний тусгаар тогтнол; **үндэс угсаа** (угсаа гарал); **яс үндэс** (угсаа; *яс үндэс ялгаварлах*).

ҮНДЭСГҮЙ сууригүй, үндэс байхгүй, иш баримтгүй; *үндэсгүй модыг яаж суулгах билээ; түүний хэлж байгаа зүйл нь ямар ч үндэсгүй зүйл.*

ҮНДЭСЖИХ үндэстэй болох, үндэс бий болох.

ҮНДЭСЖҮҮЛЭХ үндэсжихийн үйлдүүлэх хэв.

ҮНДЭСЛҮҮЛЭХ үндэслэхийн үйлдүүлэх хэв.

ҮНДЭСЛЭГ үндэс сайтай, бат бэх үндэстэй.

ҮНДЭСЛЭГДЭХ үндэслэхийн үйлдэгдэх хэв.

ҮНДЭСЛЭЛ уламжлал, уг иш, бат, үндэслэн гаргасан зүйл, санаа бодол.

ҮНДЭСЛЭХ 1. ургамлын үндэс бий болох, үндэс гарч ургах; 2. ш и л ж с э н үйл явдалд иш үндэс гаргаж авах, тулгуурлах; *үүгээр үндэслэн дүгнэж үзэхэд... гарсан зааврааас үндэслэх.*

ҮНДЭСТЭЙ үндэс бүхий, иш баттай, уламжлалтай; *үндэстэй хэрэг; үндэстэй санаа.*

ҮНДЭСТЭН хэсэг бүлэг хүмүүсийн хэл, газар нутаг, эдийн засаг, сэтгэл санааны агуулга чанараар нэгийн улмаас түүхийн ёсоор бий болсон батжилтай нэгдэл, нийлэл; *үндэсний хэл; нийгэм журамт үндэстэн; Монгол үндэстэн; Нэгдсэн үндэстний байгууллага.*

ҮНЖРЭГ зэвгүй сум.

ҮНС (ЭН) галд шатаж дуусаны хойно гарах тоосорхог саарал зүйл; *тамхины үнс; хүжний үнс; үдийн газар нэргүй, үнсний цаана мөргүй з ү й р;* **үнсэн товрог болох** (юм бүрмөсөн бүрлэх, сүйдэх); **үнсэн саарал** (зэвхий саарал өнгө): **үнсэн буу тавих** (а. осолдож, галд ус оруулан үнс бүрүүлах; б. ш о о д с о н орон гэрийн дотор бохир муухай байдалтай байх); **үнсэн самбар** х у у ч и р с а н (үнс түрхэж, бичиг бичих ба зураг зурах зэрэгт хэрэглэх модон самбар); **үнсэн өнгө** (цагаавтар өнгөнд харавтархан өнгө хольцсоны нь).

ҮНСГҮЙ урамгүй, хий моригүй, өнгө жавхаагүй; *үнсгүй царай; үнсгүй өнгө.*

ҮНСДҮҮЛЭХ үнсдэхийн үйлдүүлэх хэв.

ҮНСДЭХ юманд үнс түрхэх.

ҮНСИЙЛГЭХ үнсийхийн үйлдүүлэх хэв.

ҮНСИЙХ үнсгүй болох, урам зоригүй болох.

ҮНСЛҮҮЛЭХ үнслэх I-ийн үйлдүүлэх хэв.

ҮНСЛЭХ I үнсдэх.

ҮНСЛЭХ II байн байн үнсэх.

ҮНСТЭХ I зуух, тулга зэрэгт үнс ихтэй болох; *зуух үнстэх.*

ҮНСТЭХ II үнэртэх.

ҮНСҮҮЛЭХ үнсэхийн үйлдүүлэх хэв.

ҮНСЭХ 1. үнэрлэх, үнэр авах; 2. хайрлаж энхрийлэн хамар уруулыг тулгаж үнэрлэх; *хүүхдээ үнсэх.*

ҮНХЭЛБЭР хутга, сэлмийн балтгийн ойрхи ирт өмсгөсөн төмөрлөг; *сэлэмний үнхэлбэр.*

ҮНХЭЛЦЭГ зүрхний бүрээс, мөн түүнд мах чихэж битүүлсэн хоол; **үнхэлцэг нь хагарах** (ихэд айх).

ҮНЭ I 1. мөнгөөр бодсон өртөг; **үнэ өртөг** х о р ш.; *үнэ хямдрах;* **үнэ төлбөр** (а. өр; б. өртөг); **үнэ төлбөргүй** (а. өр ширгүй; б. өртөггүй; *гэрийн эсгий үнэ төлбөргүй олгосугай);* **үнэ нэмэх** (өртгийг нэмэх); **үнэ тогтоох** (аливаа юмны өртгийг тогтоох); **үнэ зохиох** (аливаа юмыг хийж үйлдэхэд зарцуулсан зүйл, ажилчны хүч хөлсийг таацуулан бодож өртгийг зохиох); **үнэ хайрлахгүй** (их өртгөөр: *үнэ хайрлахгүй худалдан авах*); **үнэ таацах** (өртөг тохиролцох); **үнэ тохирох** (үнэ таацах); **үнэ арцах** (худалдах юмны өртгийг их бага гэж маргалдах); **үнэ буух** (юмны өртөг буурах); **үнэ бүхий** (үнэтэй); **үнэ бүхий зүйл** (үнэтэй эдлэл); **үнэ өгөх** (бусдын худалдах юманд өөрийн авах гэж хүссэн үнийг хэлэх); **үнэд хүрэх** (худалдах гэсэн юмны үнэ өндөр болох); **үнэ хаялцах** (нэг юмыг хэдэн хүн авахаар харилцан тэмцэж үнэ нэмэлцэх); **үнэ хадах** (юмны үнэ асар өндөрдөх); **үнэ засагч** (худалдааны газрын юмны үнийг тогтоон хэлэлцэх хүн); 2. нэр алдар, алдар хүнд; *үнээ барах.*

ҮНЭ II а м ь т а н хүрнэтэй адилхан, нарийн биетэй, шаравтар үстэй амьтан.

ҮНЭГ (ЭН) а м ь т а н нохойн намын, хөх өөр өсөх араатан мөн түүний арьс; *хар үнэг; халтар үнэг; улаан үнэг; үнэгэн малгай; үнэгэн дах; үнэгэн дотор; үгний үнэн нь сайхан, үнэгний улаан нь сайхан* з ү й р; *үнэгний арьс; үнэгний нүх;* **үнэгэн заль, үнэгэн мэх** (сайхан үг хэлж мэхлэх заль мэх); **үнэгэн сүүл** у р г а м а л (нуга, чийгтэй газраар ургадаг үет ургамлын язгуурын, олон наст ургамал, Монгол орны хангай нутгаар урган).

ҮНЭГЭНЦЭР а м ь т а н үнэгтэй адил бөгөөд модонд авирч чаддаг араатан.

ҮНЭГЧЛЭХ 1. үнэгэнд гөрөөчлөх; 2. нялх хүүхдийн зүүдлэн инээмсэглэх.

ҮНЭДЭХ үнэ нь ихдэх; *авах санаа байвч үнэдээд болохгүй байв.*

ҮНЭЛҮҮЛЭХ үнэлэхийн үйлдүүлэх хэв.

ҮНЭЛШГҮЙ 1. асар сайн, маш чухаг; *үнэлшгүй эрдэнэ;* 2. үнэ өртөг тогтоож болшгүй, үнэ хийх аргагүй; *үнэлшгүй тусламж.*

ҮНЭЛЭГДЭХ үнэлэхийн үйлдэгдэх хэв.

ҮНЭЛЭЛТ үнэлэх үйлийн нэр, үнэлэх нь; *үнэлэлт авах; үнэлэлт өгөх.*

ҮНЭЛЭХ 1. юманд үнэ хөлс тогтоох; **үнэлэн авах** (тохирсон, бага биш үнийг өгч авах); **биеийн хүчин үнэлэх** (хөлсний ажил хийх); **үнэлсэн хүч** (хөлсөлж авсан хүн); 2. юмны зэрэг, хирийг тогтоох; *үнэлэн үзэх; дүгнэн үзэх.*

ҮНЭМЛЭХ 1. үнэмших, үнэнд үзэх 2. юманд баримт болгох бичиг; *сургууль төгсгөсөн үнэмлэх; зам явах үнэмлэх.*

ҮНЭМЛЭХҮЙ алив юмны маргаангүй зөв; *үнэмлэхүй үнэн.*

ҮНЭМШИХ үнэн гэж итгэмжлэх; *би анхандаа үнэмшихгүй байв; үнэмшмээргүй зүйл.*

ҮНЭМШҮҮЛЭХ үнэмшихийн үйлдүүлэх хэв.

ҮНЭН жинхэнэ, бодит байдалд тохирох, худал ташаа биш; *үнэн хэрэг; үнэнийг хэлэх; үнэн үгтэй; үнэн үг шар тос; үнэнээр явбал, үхэр тэргээр туулай гүйцэх* з ү й р; *үнэн үг хэлсэн хүнд хүн өшөөтэй, үхэр унасан хүнд нохой өшөөтэй* з ү й р; **объектив үнэн** (байгалийн хуулиудын тухай туршлага практикаар нотлогдсон шинжлэх ухааны үндэслэл); **туйлын үнэн** (харьцангуй үнэнүүдийн хөгжилд тэдгээрийн нийлбэрээс бүрэлддэг бөгөөд юмыг гүйцэд лавтай мэдсэн мэдлэгийн үр дүнд гарах үнэн); **харьцангуй үнэн** (шинжлэх ухааны байнгын хөгжлийн явцад туйлын үнэнд улам улмаар ойртож байгаа мэдлэг); **үнэн шудрага** (шулуун шудрага); **чин үнэн** (маш шудрага, огтхон ч худал биш); **үнэн гол** (үнэн зүрх, үнэн санаа): **үнэн зүрх** (шудрага сэтгэл); **үнэн сэтгэл** (шудрага сэтгэл, хуурамч биш сэтгэл).

ҮНЭНХҮҮ үнэн, лав үнэн, чин үнэн; *үнэнхүү санаанаасаа туслах гэсэн юм.*

ҮНЭНЧ шудрага, үнэнээр явагч, хуурч мэхэлдэггүй; *үнэнч нөхөр; эх оронд үнэнч зүтгэх.*

ҮНЭНЧИРХЭХ үнэнч байдал гаргах, үнэнчээ гайхуулах.

ҮНЭНЧЛЭХ үнэнчээр явах.

ҮНЭР хамрын сэрэгдэхүүн; **үнэр танар** х о р ш.; *сайхан үнэр; хурц үнэр;* **үнэр ханхлах** (үнэр их гарах); **үнэр авах** (ан амьтан, хүний үнэр сэрэх); **үнэр гаргах** (а. үнэр бий болгох; б. муухай үнэр үнэртүүлэх); **үнэр орох** (а. юмны өмхийрөн завдах; б. юманд бусдын үнэр халдах); **үнэр гутах** (муухай үнэртэх); **үнэр анхилах, үнэр ханхлах** (ямар нэгэн үнэр хамарт сэрэгдэх); **хүний үнэрээ алдах** (хүний шинжгүй зан гаргах).

ҮНЭРГҮЙ сэрэгдэх үнэрийн зүйлгүй; **хүний үнэргүй** (хүний чанар ханилгаагүй).

ҮНЭРЛҮҮЛЭХ үнэрлэхийн үйлдүүлэх хэв.

ҮНЭРЛЭХ 1. юмны үнэрийг авахаар шиншлэх; *үнэрлэж үзэх;* 2. үнсэх, таалах; *хүүгээ үнэрлэе;* 3. ш и л ж с э н сэжиг төрөх, анир мэдэх; *нэг юм үнэрлэсэн бололтой.*

ҮНЭРДҮҮЛЭХ үнэрдэхийн үйлдүүлэх хэв; *эм үнэрдүүлэх.*

ҮНЭРДЭХ үнэр авах, үнэр сэрэх, үнэр мэдэх.

ҮНЭРТ анхилах үнэр бүхий зүйл; *үнэрт ус; үнэрт хүж; үнэрт цуу;* **үнэрт ногоо** у р г а м а л (навч суйхын навчинд адил болоод ногоон, амт үнэр ихтэй нэгэн зүйл ногоо, хүн идэнэ).

ҮНЭРТҮҮЛЭХ үнэртэхийн үйлдүүлэх хэв.

ҮНЭРТЭЙ үнэр бүхий; *сайхан үнэртэй; өмхий үнэртэй; үнэртэй ус.*

ҮНЭРТЭН хүжис, сайхан үнэр бүхий юмс; *үнэртэн хүжсийн зүйл.*

ҮНЭРТЭХ 1. үнэр сэрэгдэх; *юу үнэртэж байна?* 2. үнэрлэх.

ҮНЭРХҮҮ үнэрхэг, тунирхаг, тунирхуу; *үнэрхүү хүн.*

ҮНЭРХҮҮЛЭХ үнэрхэхийн үйлдүүлэх хэв.

ҮНЭРХЭГ үнэрхэх, тунирхах зан байдалтай.

ҮНЭРХЭХ 1. худалдах юмандаа их үнэ дуудах; 2. ш и л ж с э н тунирхах, чадахгүй мэдэхгүй гэж боох, маяглах; үнэрхэх **тунирхах** х о р ш.

ҮНЭС үнс.

ҮНЭСДҮҮЛЭХ үнэсдэхийн үйлдүүлэх хэв.

ҮНЭСДЭХ үнсдэх.

ҮНЭСЛЭХ үнсдэх.

ҮНЭСТЭХ үнстэх.

ҮНЭСҮҮЛЭХ үнэсэхийн үйлдүүлэх хэв.

ҮНЭСЭХ үнсэх.

ҮНЭТ үнэтэй.

ҮНЭТЭЙ 1. үнэ бүхий; *их үнэтэй; хямд үнэтэй; хорин мөнгөний үнэтэй;* 2. маш их үнэ бүхий; *тун үнэтэй эд; ясан үнэтэй юм бэ.*

ҮНЭТЭЙДЭХ хэтэрхий үнэтэй болох; *арай л үнэтэйдээд байх шив дээ.*

ҮНЭТЭХ хэтэрхий үнэтэйдэх, улмаар үнэтэй болох.

ҮНЭХЭЭР нээрэн, магад, үнээр; *үнэхээр гайхалтай; би үнэхээр чингэж бодов.*

ҮНЭЭ гурваас дээш насны эм үхэр; *монголын үнээ; сарлагийн үнээ; үнээний сүү;* **сувай үнээ** (хээлгүй үнээ); **хусран үнээ** (тугалгүй, саамгай үнээ).

ҮНЭЭР үнэхээр, магад, лавтай.

ҮНЭЭРЭЭ нээрэн, үнэхээр.

ҮНЭЭРЭН мөн, лав, тийм; *үнээрэн тийм шүү!*

ҮР I шинэ махбод, амьтныг үүсгэж бий болгогч бодис, уураг, аливаа бодисоос үүдэн гарч хойшид залгамжлах хөрөнгө болох юм; **үр хөрөнгө, үр тариа, үр үндэс** х о р ш.; *тариа ургамлын идээ үр;* **үрийн тос** (ургамлын үрийн зүйлээс гаргаж авсан тос): **үр цөмөө** (жимс тарианы үр); **үр сонгох** (үр болгохын тул тарианы түрүүг сонгон түүж авах); **үр цацах, үр тарих** (тарих үрийг тариалангийн газарт сацлан орхих); **үр шимийн мал** (аливаа эм мал); **үрт оронгор** у р г а м а л (зэллэн ургах нэгэн зүйл ногоо, сондуу бий, навчийг түүхийгээр иддэг).

ҮР II хүүхэд; **үр хүүхэд, үр ач** х о р ш.; *үрийн үрд үүрд жаргах болтугай! эхийн сана үрд; үрт хүний үрүү нойтон.*

ҮР III үйл ажлын дүн; **үр ашиг, үр дүн** х о р ш.; *хичээсний үрээр бүтэв; явсны үрээр олов; үнэн нь өмнөө, үр нь хойноо* с э ц э н.

ҮРВЭЛЗҮҮЛЭХ үрвэлзэхийн үйлдүүлэх хэв.

ҮРВЭЛЗҮҮР түргэн сүрвэлзүүр зан байдалтай; *үрвэлзүүр зантай хүн ;үрвэлзүүр ааштай мал.*

ҮРВЭЛЗЭХ 1. галын дээш дүрэлзэн шатах; *гал үрвэлзэх; үрвэлзэн асах;* 2. үрвэлзүүр байдал гаргах.

ҮРГҮЙ I үр залгамжлал байхгүй.

ҮРГҮЙ II ашиг тусгүй; *үргүй зардал; үргүй ажил; ямар ч үргүй хөдөлмөрөөр юугаа хийх вэ.*

ҮРГЭДЭГ зан асар уульхай, сочих натгах үлэмжхэн морь мал, үргэмтгий.

ҮРГЭЛЖ 1. тусгаар биш хамт, залгаа; *нэг үргэлж эд бөс; хэрэг явдал залгаа үргэлж; үргэлж хашаа;* 2. байнга, туж, турш, ямагт, тасалдалгүй; *энэ өдөр үргэлж салхилав; худалдаачин хүн үргэлж ашиг эрнэ; би хотод үргэлж суудаг.*

ҮРГЭЛЖИД үргэлж ямагт, хэзээд, туршид.

ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ үргэлжлэхийн үйлдүүлэх хэв.

ҮРГЭЛЖЛЭЛ үргэлж юмны хагас, зарим нь; *түүхийн үргэлжлэл; үүний үргэлжлэл нь дараагийн дугаарт.*

ҮРГЭЛЖЛЭХ юмны тасалдал, тасралгүй залгалдаагаар болох; *ажил үргэлжлэх; дуу үргэлжлэх; хичээл үргэлжлэх.*

ҮРГЭМТГИЙ морь малын үргэдэг зантай, үргэмхий; *үргэмтгий морь.*

ҮРГЭМХИЙ үргэмтгий.

ҮРГЭХ мал, гөрөөс зэргийн амьтны айн сочиж илбэс. дэлбэс хийх ба буруулан дутаах; *ямар юмнаас морь үргэв; хонь үргэх чимээ гарав, гарч хар!*

ҮРГЭЭЛЭГ (ЭН) ан агнахад ан гөрөөсийг тосч сууринд суусан хүний зүг үргээж явуулахы нь; *үргээлгэнд гарах*

ҮРГЭЭХ үргэхийн үйлдүүлэх хэв, үргэхэд хүргүүлэх; *чоно үргээх; үргээж туух.*

ҮРДЭС I эсгэсэн өөлсөн, эвдэрсэн хэмхэрсэн зэргээс гарсан ялимгүй өөдөс юм; **үрдэс өөдөс** х о р ш..

ҮРДЭС II хатаасан үр жимсийн зүйл; *мойлны үрдэс; нэрсний үрдэс.*

ҮРЖИГДЭХҮҮН үржигч, үржүүлэгч; *үржигдэхүүний байрыг солиход үржвэрийн чанар өөрчлөгдөхгүй.*

ҮРЖИЛ юмны үлэмж төрж дэлгэрэхий нь; *үржил мал; үржил сайтай; үржил төл; үржил сүрэг* ☆ **үржил жимс** у р г а м а л (мод цэцэглэхгүй, жимс салаа найлзуураас ургадаг, анарын мэт том, өнгө харавтар улаан, амт хүчтэй; чанаж иддэг нэг зүйл жимс).

ҮРЖИЛГҮЙ үрждэггүй, үржил муутай.

ҮРЖИЛТ үржил бүхий.

ҮРЖИЛТЭЙ үржил бүхий, үржил сайтай; *үржилтэй хөрс; үржилтэй мал.*

ҮРЖИХ аливаа юм улмаар нэмэгдэн төрж олшрох, дэлгэрэх; *мал үржих; үр тариа үржих.*

ҮРЖЛЭГ үржих үйлийн нэр; *үржлэг сайн; үржлэг муу.*

ҮРЖҮҮЛЭГ үржүүлэх үйлийн нэр; *үржүүлгийн мал; үржүүлгийн ажил; үржүүлгийн аж ахуй.*

ҮРЖҮҮЛЭГЧ 1. үржүүлэх үйлийг эрхлэгч; *гахай үржүүлэгч;* 2. үржүүлж байгаа тоо; *үржүүлэгч нь хэд вэ?*

ҮРЖҮҮЛЭХ үржихийн үйлдүүлэх хэв; *мал үржүүлэх; тоо үржүүлэх.*

ҮРЛЭГ үрэх нь; *мөнгөний үрлэг хийгээд юугаа хийх вэ;* **үрлэг зарлага** (хүний хоол хувцас зэрэгт зарцуулах зарлага).

ҮРЛЭГЧ үрдэг, үрэмтгий.

ҮРЛЭХ 1. тариа тарихад хөрөнгө болгон үр орхих булах; 2. тариа ургамлын зүйлд үр цөмөө суух.

ҮРЛЭЭЧ үр сацагч машина.

ҮРС олон үр; ач үрс; **үрс гаргах** х у у ч и р с а н (малын сүүг эцэглэж тайх үйл гүйцэтгэх, ёс заншил янз янз; *үхрийн үрс гаргах; гүүний үрс гаргах; тэмээний үрс гаргах; хонь ямааны үрс гаргах*).

ҮРСЛҮҮР ургамлын үрийг суулгаж ургуулах газар; *цэцгийн үрслүүр.*

ҮРСЛЭХ үрийг суулгах.

ҮРСЭГ амьтны үр зулзагаа эрэх хүсэх нь нэндүү.

ҮРСЭХ амьтны үр зулзагаа асар их эрэх хүсэх.

ҮРТЭЙ I үр бүхий.

ҮРТЭЙ II үр ашиг, үр дүн бүхий.

ҮРТЭС алив юмны үүрмэг, бяцхан хог; *модны үртэс; төмрийн үртэс; талхны үртэс.*

ҮРҮҮ эрүү.

ҮРЧВЭЛЗЭХ үрчилзэх.

ҮРЧГИЙ үрчгэр, арчгар.

ҮРЧГЭР юмны атирсан хунирсны нь; *үрчгэр даавуу; үрчгэр шир; үрчгэр арьстай; үрчгэр магнай.*

ҮРЧГЭРДҮҮЛЭХ үрчгэрдэхийн үйлдүүлэх хэв.

ҮРЧГЭРДЭХ хэтэрхий үрчгэр болох.

ҮРЧГЭРТЭХ үрчгэр тогтох, үрчгэр байдалтай болох.

ҮРЧГЭЭР үрчгэр.

ҮРЧИГНҮҮЛЭХ үрчигнэхийн үйлдүүлэх хэв.

ҮРЧИГНЭХ үрчгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ҮРЧИЙЛГЭХ үрчийхийн үйлдүүлэх хэв.

ҮРЧИЙХ гөлгөр толигор биш атриа үрчлээтэй болох; *хувцас үрчийх; хөгширч нүүр үрчийх; чи битгий үрчийгээд бай.*

ҮРЧИЛЗҮҮЛЭХ үрчилзэхийн үйлдүүлэх хэв.

ҮРЧИЛЗЭХ 1. үрчгэр юмны байн байн хөдлөх; 2. зөөлөн нимгэн торго бөс мэтийн урвалзах.

ҮРЧИС: үрчис үрчис хийх үрчгэр юмны байн байн хөдлөх, үрчвэлзэх, үрчилзэх.

ҮРЧЛҮҮЛЭХ үрчлэхийн үйлдүүлэх хэв.

ҮРЧЛЭХ бусдын хүүхдийг өөрийн болгон тэжээх; *хүүхэд үрчлэх.*

ҮРЧЛЭЭ атриа, үрчрээ; *магнайн үрчлэв.*

ҮРЧЛЭЭС үрчгэр болсон тэр хэсэг; *үрчлээс гарчээ.*

ҮРЧРЭЭ үрчлээ.

ҮРЭВДЭС үрдэс, модыг хөрөөдсөн буюу үрсний нунтаг.

ҮРЭВСҮҮЛЭХ үрэвсэхийн үйлдүүлэх хэв.

ҮРЭВСЭЛ үрэвсэх үйлийн нэр; *үрэвсэл их; үрэвсэл бага; уушигны үрэвсэл.*

ҮРЭВСЭХ 1. юмны улмаар нэмэгдэх, ихдэх, бадрах, дэлгэрэх; 2. тухайн газарт хавдах, халуу оргих зэргээр өвдөх өвчний явц; *уушиг үрэвсэх.*

ҮРЭВТГЭЛ үрэвтгэх үйлийн нэр.

ҮРЭВТЭЛ үрэх багаж; *модны үрэвтэл; төмрийн үрэвтэл.*

ҮРЭВТЭХ юмны улмаар бадрах, тархах; *гал түймэр улам үрэвтэх; яр түүхий үрэвтэх;* үрэвсэх ч гэдэг.

ҮРЭГДҮҮЛЭГЧ бүрэлтэгч, шамшигдуулагч, сүйтгэгч.

ҮРЭГДҮҮЛЭХ 1. үрэгдэхийн үйлдүүлэх хэв; 2. шамшигдуулах, сүйтгэх, бүрэлгэх.

ҮРЭГДЭЛ үрэгдэх үйлийн нэр, үрэгдсэн нь; **үрэгдэл чирэгдэл, үрэгдэл шамшигдал** х о р ш.

ҮРЭГДЭХ үрэхийн үйлдэгдэх хэв.

ҮРЭЛ бөөрөнхий, мөхлөг, рилбэ; **үрэл сум** (жижиг мөхлөгүүдээр хийсэн бөгөөд тусгалын газар хүрмэгц дэлбэрдэг нэг зүйл сум).

ҮРЭЛХЭГ: үрэлхэг хулс у р г а м а л байдал хулс мэт, улаан буурцаг хонгорцоглож ургадаг нэгэн зүйл мод; **үрэлхэг цэцэг** у р г а м а л (цэцгийн өнгө хүрэн улаан, найм есөн хэлтэстэй, цэцэг зулгарч, тоорцог хонгорцоглон үрэлдэг).

ҮРЭМ: үрэм шороо чанар сул, авд бөмнөлдөхгүй шороо).

ҮРЭМТГИЙ юм үрж сйтгэдэг зантай, үрэмхий; *үрэмтгий хүн.*

ҮРЭМХИЙ юм хумыг хайр гамгүй үрэх зантай; *үрэмхий хүн.*

ҮРЭН: үрэн таран үрэгдэж үгүй болох; *үрэн таран хийх.*

ҮРЭХ I юм хумыг юмаар харж хавиран засах; *үрэвтлээр үрэх; хуурайгаар үрэх; алчуураар үрэх; гутал өсгий үрээд байна.*

ҮРЭХ II эд хөрөнгө юмыг бүрэлгэх, сүйтгэх; **үрэх тарах, үрэх сүйтгэх, үрэх шамших** х о р ш.; *эд хөрөнгөө үрэх.*

ҮРЭХ III аливаа хэрэг зүйлийг хэрэгсэхгүй болгох; *хэргий нь үрэх.*

ҮРЭХ IV юманд үйрмэг нунтаг юм сацах, холих, бүрхэх; *гурил үрэх; давс үрэх; шороо үрэх.*

ҮРЭЭ (Н) гурваас тав хүртлэх насны эр адуу; *шүдлэн үрээ; хязаалан үрээ; соёолон үрээ; үрээ морь нь цогиотой доо хөө хөө, унэгэн хөнжил дэлгээтэй дээ хөө хөө* (дуу); **үрээн азрага** (агтлаагүй үрээ адуу).

ҮРЭЭНЦЭР сая шүд гүйцэх эсэх орчмын эр адуу.

ҮС 1. хүн амьтны арьсанд ургах, эвэрлэгээр бүтсэн ширхэглэг зүйл: **үс авах** (хүний толгойн үс ба арьс шир зэргийн үсийг хутга мэтээр зүйлэн хусч унагаах); **үс хагалах** х у у ч и р с а н (эмэгтэй хүнийг эрд богтлоход толгойн үсийг голоор нь хувааж салгах); **үс зайдах** (толгойн үсийг орой дээрээ зангидах буюу сүлбээрлэн тогтоох); **үс засах** (хүний толгойн үсийг янзлах); **үс тавих** (хүний толгойн үсийг авахгүйгээр зориуд ургуулах); **үс даахирах** (үс ээдрэн ширэлдэх); **үс самнах** (хүний үс гэзэг зэргийн ээдэрснийг гаргах мэтэд самаар шүүрдэх, сүлжих); **үс ширэлдэх** (үс ихэд даахиран бөөгнөрөх); **үс сэгсийх** (амьтны үс ихэд ургаж сэгсгэр болох); **үс шанхлах** (а. хүний толгойн үс ихэд ургасныг хоёр тийш хагалж унжуулах; б. хүний толгойн үсийг зүйл бүрээр сайхан болгон боох, сүлжих): **үсний даахь** (үсний ихэд ээдэрч бөөгнөрсний нь); **үсний сэв** (үсний даахирсан, ээдэрснийг самнахад зулгаагдаж гарсан үс); **үс татах** (юманд үс тохируулан хадах; *малгайд үс татах);* **ангийн үс** (үслэг ангийн арьс); 2. ургамлын эрхтэнд ургасан ширхэглэг үслэг юм; 3. ялзарсан, гутсан юман дээгүүр тогтсон үслэг зүйл.

ҮСДҮҮЛЭХ 1. үсдэхийн үйлдүүлэх хэв; 2. үсдэгдэх.

ҮСДЭГДЭХ үсдэхийн үйлдэгдэх хэв.

ҮСДЭХ үснээс шүүрч чангаах.

ҮСЛҮҮЛЭХ үслэхийн үйлдүүлэх хэв.

ҮСЛҮҮР шингэн нялцгай идээ **хоолны үс** хялгасыг шүүрдэж авах хэрчлээст мод.

ҮСЛҮҮРДЭХ үслүүрээр **үс** хялгасыг **нь** шүүрдэх.

ҮСЛЭГ сахлаг, үс арвин, үс сайтай; *үслэг арьс; үслэг ан амьтан.*

ҮСЛЭХ 1. зүлгүүр зэрэг зарим **юманд үс** хялгас тогтоон хийх; *сойз үслэх; малгай үслэх;* 2. арвай буудай зэргийг чийглэн нүдсээр **хи**вэг хальсыг унагаах; *арвай үслэх;* 3. идээ хоол зэрэг юманд орсон үсийг цэвэрлэж **арил**гах; *тос үслэх.*

ҮСРҮҮЛЭХ үсрэхийн үйлдүүлэх хэв.

ҮСРЭХ I 1. юмны чавхдан ойх; *чулуу үсрэн ойв;* 2. дэвхрэх, харайх, дүүлэх; *мод өөд үсрэн авирав.*

ҮСРЭХ II юман дээрээс **ус хаях, сүрчих.**

ҮСТ 1. үс бүхий; **үст хорхой** а м ь т а н (биедээ үстэй өт); 2. нарийн үс бүхий ангийн арьс; **үст ан** (үнэг, булга зэргийн үнэ ихтэй үс бүхий ан.

ҮСТҮҮЛЭХ үстэхийн үйлдүүлэх хэв.

ҮСТЭЙ үс бүхий юм, үс ихтэй; *үстэй дээл; үстэй амьтан.*

ҮСТЭХ 1. юманд үс наалдаж тогтох; 2. **юм** гутаж муудан дээгүүр нь **үс мэт зүйл бүрхэх.**

ҮСХИЙ үслэг.

ҮСЧ (ИН) үс засагч; *үсчний газар.*

ҮСЧИХ 1. байн байн үсрэх; 2. ш и л ж с э н тал бүр тийш муу ааш гарган халдах; *хүн бүр өөд үсчих.*

ҮСЧҮҮЛЭХ үсчихийн үйлдүүлэх хэв.

ҮСЭГ аль нэгэн бичгийн үндсэн махбод болох цагаан толгойн тэмдгүүд; **үсэг бичиг** х о р ш.; *Монголын шинэ үсэг; латин үсгээр бичих; А үсэг; үсэг бичиг үл мэдэх явдлыг арилгах эрхэм зорилго;* **үсэг өрөгч** (ном бичиг хэвлэхэд үсгийн хэвийг нийлүүлэн өрөх хүн); **үсэг засагч, үсэг хянагч** (хэвлэлийн газар хэвлэсэн бичиг номын алдаа мадгийг засах хүн); **үсгийн хэв** (а. үсгийн бар; б. үсгийн хэлбэр); **үсгийн дүрэм** (зөв бичих дүрэм: *үсгийн дүрмийн төлө бичиг*); **гарын үсэг** (гараараа бичсэн өөрийн нэр *гарын үсэг зурах*).

ҮСЭГЛҮҮЛЭХ үсэглэхийн үйлдүүлэх хэв.

ҮСЭГЛЭЛ үсэг бичиг эхлэн сурахад зориулсан ном; *үсэглэлийн зураг.*

ҮСЭГЛЭХ 1. бичгийг үсэг үсгээр дуудан унших; *үсэглэн унших; үсэглэн заах;* 2. ш и л ж с э н утга учрыг үл харгалзан өнгөц мэдэх; *үсэглэн цээжлэх.*

ҮСЭД хэтэрхий, маш, онцгой; **үсэд өөр** (маш өөр); **үсэд нэмэгдэх** (ихэд нэмэгдэх); **үсэд хол** (маш хол).

ҮСЭРГЭХ I үсрэхэд хүргүүлэх, үсргүүлэх; **дарь үсэргэх** (бууны дарийг бяцханаар шатаах тэнсэх).

ҮСЭРГЭХ II хурдан морийг тарлах; *морь үсэргэх.*

ҮСЭРХИЙЛЭХ 1. үсчих; 2. түүхий яр зэргийн халдварлан шинэ газар нэмж гарах.

ҮТРЭМ тариа цайруулах газар; *тарианы үтрэм.*

ҮТРЭН: үтрэн дайрах шууд буруушаахгүй, бүс газрыг зааж хувилган хэлэлцэх

ҮТРЭХ шүргэх, хавирах.

ҮТРЭЭ умайн хоолой.

ҮТЭЛ энгийн, эгэл, сул, зүгээр; **үтэл хүн** (сул хүн); **үтэл суух** (зүгээр суух); **үтэл төрөлхтөн** (эгэл төрөлхтөн); **үтэл зүгээр** (энгийн зүгээр).

ҮТЭР даруй, хурдан, түргэн, бушуу; *үтэр ир!* **үтэр түргэн** х о р ш..

ҮТЭРЛҮҮЛЭХ үтэрлэхийн үйлдүүлэх хэв.

ҮТЭРЛЭХ түргэлэх, хурдлах.

ҮТЭЭР эмээлийн бүүрэг хавтас хоёрын нийлэлтийн газрыг үдсэн сур.

ҮТЭЭРХҮҮ үтээрхэг.

ҮТЭЭРХҮҮЛЭХ 1. үтээрхэхийн үйлдүүлэх хэв; 2. үтээрхэгдэх.

ҮТЭЭРХЭГ атаархах, мөчөөрхөх зантай.

ҮТЭЭРХЭГДЭХ үтээрхэхийн үйлдүүлэх хэв.

ҮТЭЭРХЭХ атаархах, мөчөөрхөх, үтээрхүү зан гаргах.

ҮТЭЭРЭХ өршөөснийг санахгүй, тусыг мартаж тэсрүүлэх.

ҮҮ I асуух үг эм үгийн дараа орно; *ирсэн үү?*

ҮҮ II амьтны биед гардаг эвэрлэг зүйл; *гар дээр үү гарав;* **өмөн үү** (нэгэн зүйл хорт хавдар өвчин).

ҮҮВЭР: үүвэр түүвэр эрж түүж нийлүүлсэн юм; *үүвэр түүвэр юмаар хийсэн зүйл.*

ҮҮГНЭХ үхрийн богино дуугаар уртхан дуугарах.

ҮҮГЭХ юмны нүх цоорхой, хөндий зэргээс жихүүн салхи үлээх; **үүгэх сүүгэх** х о р ш.; *орны араас салхи үүгэж байв; цонхоор үүгэх.*

ҮҮГЭЭР энэ хавиар гэж заах **төлөөний** үг, энүүгээр; **үүгээр түүгээр** (энүүгээр тэрүүгээр); **үүгээр үзвэл** (энэ байгаагаар үзвэл); **үүгээр бодвол** (энэ байгаагаар бодвол).

ҮҮД (ЭН) орох гарах хаалга; **үүд хаалга** х о р ш.; *үүд нээх; үүд хаах; үүдэнд суух; хашааны үүд; гэрийн үүд; үүд сөхөх; эсгий үүд;* **үүдэн шүд** (амьтны хушуу этгээдэд ургасан шүд); **үүднээс** (санаанаас; *туслахын үүднээс; бүтээхийн үүднээс; зайлахын үүднээс*).

ҮҮДЭЛ үүсэл, гарал, эхлэл.

ҮҮДЭХ үүсэх, эхлэх.

ҮҮДЭЧ үүд харгалзагч.

ҮҮЛ (ЭН) I агаарт хуран цугларсан усны уур; *сэмжин үүл; үүл арилбал нарыг олж үзнэ, өшөөтөн арилбал сайхныг олж үзнэ* з ү й р; **үүлэн хээ** (нэг зүйл хээ).

ҮҮЛ II 1. амьтны нүдэнд бүрхэн тогтсон цэгээн зүйл; *нүдний үүл; нүдэндээ үүлтэй хээр морь;* **үүл унах** (цагаа унах). 2. эрхний хаалтыг зарим нутагт нэрлэх нэр.

ҮҮЛГЭР хөнгөн, хийсвэр сандрамхай; **үүлгэр дүүлгэр** х о р ш..

ҮҮЛГЭРДҮҮ хөнгөн хийсвэр, сандрамхай зан байдалтай.

ҮҮЛГЭРДҮҮЛЭХ үүлгэрдэхийн үйлдүүлэх хэв.

ҮҮЛГЭРДЭХ сандрах, тэвдэх, яарах, бачимдах, хэтэрхий үүлгэр байдал гаргах.

ҮҮЛГЭРДҮҮЛЭХ үүлгэртэхийн үйлдүүлэх хэв.

ҮҮЛГЭРТЭХ үүлгэр байдалтай болох, үүлгэр зан гаргах.

ҮҮЛДЭР удам угсаа; *малын үүлдэр сайжруулах; нутгийн үүлдрийн мал; үүлдэр сайтай.*

ҮҮЛТ үүл бүхий; *үүлт тэнгэр; үүлт нүд.*

ҮҮЛТЭЙ үүл бүхий; *үүлтэй тэнгэр; нүдэндээ үүлтэй.*

ҮҮЛТЭХ үүлтэй болох.

ҮҮЛШИХ үүл бий болох шинж орох, үүл гарах.

ҮҮЛЭРХҮҮ 1. үүлэрхэг; 2. үүл мэт.

ҮҮЛЭРХЭГ үүлтэй, үүл ихтэй.

ҮҮН энэ гэж заах төлөөний үг; *үүний морь хаа байна? үүнийг чи ав! үүнээс чинь би хэдийг авах вэ? үүгээр чи юу хийх вэ? үүнтэй хамт явж морио олоод ир!*

ҮҮНИЙХ үүний гэж хамаадуулах төлөөний үг; *энэ дэвтэр үүнийх.*

ҮҮНЧЛЭН энэчлэн, энэ мэтэчлэн, үүн шиг; **үүнчлэн түүнчлэн** х о р ш..

ҮҮР I олон нийтийн байгууллагын анхан шатны зохион байгуулалт; *намын үүрийн нарийн бичгийн дарга; эвлэлийн үүрийн товчоо.*

ҮҮР II зарим амьтны орогнох оромж; *шувууны үүр; хараацайн үүр; чоныи үүр; шоргоолжны үүр.*

ҮҮР III нар мандахын өмнөх хэсэг үе; *адуундаа үүрээр мордох; үүрийн туяа;* **үүр гийх** (үүр цайх); **үүр гэгээрэх** (бараг бүрэг гэгээ орох); **үүр цайх** (гэгээ сайн орж ирэх); **үүр цайлгах** (үүр гэгээрэхэд хүрүүлэх; *явсаар үүр цайлгах; суусаар үүр цайлгах; унтсаар үүр цайлгах);* **үүр шарлах** (уул завсарласны дараа гэгээрэн ирэх); **үүрийн тэмдэг** (үүрийн гэгээ үүсэх); **үүр тэмдэгрэх** (үүрийн тэмдэг орох); **үүрийн харанхуй** (үүрийн урдханы харанхуй); **үүрийн хяраа** (үүр гэгээрэхийн өмнөхөн үе); **үүрийн бялзуухай** а м ь т а н (бялзуухайн багийн жижиг шувуу, үүр гэгээрмэгц жиргэнэ).

ҮҮР IV: **үүр түүр** бүрэг бараг, бадаг бүдэг, бүүр түүр; *одоо л үүр түүр санаанд орж байна.*

ҮҮРГЭВЧ үүрэхэд зориулсан, юм хүм агуулах сав.

ҮҮРГЭЛСХИЙХ үүрэглэн завдах, баахан үүрэглэх.

ҮҮРД хэзээд, үргэлжид, ямагт; *үүрд мөнх; үүрд бат;* **үүрдийн дурсгал** (мөнхийн дурсгал): **үүрдийн найрамдал** (мөнхийн найрамдал).

ҮҮРЖИХ I үүрд болох, мөнх болох, мөнхжих.

ҮҮРЖИХ II үүртэй болох.

ҮҮРЖҮҮЛЭХ үүржихийн үйлдүүлэх хэв. ◆

ҮҮРЛҮҮЛЭХ үүрлэхийн үйлдүүлэх хэв.

ҮҮРЛЭХ 1. үүрэнд байрлах; *шувуу үүрлэх;* 2. шилжсэн хулгайч, дайсан этгээдийн хуран бүүрлэх; *хулгайч үүрлэх; дайсан этгээд үүрлэх.*

ҮҮРМЭГ үйрмэг.

ҮҮРСЭХ адууны богино дуугаар янцгаах мэт хүхтнэн дуугарах; *гүү, унагаа харан үүрсэх; бордооны морь үүрсэх.*

ҮҮРТҮҮЛЭХ үүртэхийн үйлдүүлэх хэв.

ҮҮРТЭХ 1. үүрсэн, барьсан, ачсан юмыг дааж ядах; 2. ажил явдалдаа дийлдэх, дарагдах.

ҮҮРҮҮЛЭХ үүрэхийн үйлдүүлэх хэв.

ҮҮРЭГ 1. үүргэвч, нуруун дээр хэдрэхэд зориулан хийсэн зүйл; *хавчиг үүрэг; үүргийн араг;* 2. биедээ дааж авсан, хариуцан гүйцэтгэх зүйл; **үүрэг даалгавар, үүрэг зорилго** хорш.; *үүрэг биелүүлэх; ариун үүрэг.* ◆

ҮҮРЭГЛҮҮЛЭХ үүрэглэхийн үйлдүүлэх хэв.

ҮҮРЭГЛЭХ I үүрэх; *хүүхэд үүрэглэх; араг үүрэглэх.*

ҮҮРЭГЛЭХ II нойрмоглох, нойрмоглон дохих, нойр хүрч нүд анилдах; *сандал дээр үүрэглэн сууж байлаа.*

ҮҮРЭХ I 1. юмыг нуруун дээрээ хэдэрч тээх; *хавчиг үүрэг үүрсэн бадарч явав гэнэ; мөс үүрэх; түлээ үүрэх;* 2. шилжсэн биедээ хүлээж авах, биеэр дааж өнгөрүүлэх; *хамаг хүндийг үүрэх.* ◆

ҮҮРЭХ II үйрэх, хэмхрэх, бутрах.

ҮҮСВЭР үүсэл, эхлэл, үүдэл; *үүсвэрээсээ аваад тогсгөлөө хүртэл.*

ҮҮСГЭГЧ 1. үндэслэгч; *хувьсгал үүсгэгч; уулын спортыг үүсгэгч; Монголын пионерийн байгууллагыг үүсгэгч;* 2. үүсгэсэн этгээд, эхлэгч; *ажил үүсгэгч; хэрүүл үүсгэгч.*

ҮҮСГЭЛ үүсгэх үйлийн нэр.

ҮҮСГЭР 1. бууны сумны явах муруй зам; 2. үүсгэл.

ҮҮСГЭХ үүсэхийн үйлдүүлэх хэв, үүсэхэд хүргүүлэх.

ҮҮСЭЛ үүсэх үйлийн нэр; **гарал үүсэл** хорш..

ҮҮСЭХ үүдэх, эхлэх.

ҮҮТЭХ үү гарах; *гэр үүтэх.*

ҮҮХРЭХ хашгирах; **хашгирах** үүхрэх хорш..

ҮҮХЭРДҮҮ яаруу, бачимдуу, тэвдүү, сандруу зантай; *үүхэрдүү хүн.*

ҮҮХЭРДЭХ үүхэрдүү зан гаргах; *үүхэрдэх бачимдах хэрэггүй, өвгөн минь!*

ҮҮЦ 1. хавар идэхээр өвөл бэлтгэж хадгалсан мах; *үүц идэх; үүцний мах;* 2. шилжсэн нөөж хадгалсан юм.

ҮҮЦЛҮҮЛЭХ үүцлэхийн үйлдүүлэх хэв.

ҮҮЦЛЭХ 1. махаар үүц хийх; 2. шилжсэн юмыг ихээхнээр нөөж хадгалах.

ҮҮЧИХ байн байн үүрүүлэх.

ҮХ дотуураа муу санаалан бодох харгис хүн.

ҮХДЭЛ хүүр; **үхдэлийн идээ** (хэрээний нүд).

ҮХЛҮҮТ 1. үхэхэд хүрч ханзлан хэвтэж байгаа нь; *үхлүүт өвчтэй;* 2. юмыг бат бэх болгосон нь; *үхлүүт уях; үхлүүт хадах; үхлүүт ярилцсан.*

ҮХТГЭГЧ: үхтгэгч өвчин ухаан мэдрэл алдаж балардан муужрах өвчин.

ҮХТГЭХ ухаан мэдрэл алдаж балардах, муужрах.

ҮХҮҮЛЭХ 1. үхэхийн үйлдүүлэх хэв, үхэхэд хүргүүлэх; 2. юмыг маш сайн бэхлэх, боох; *шуудайны амыг үхүүлээд уячихсан; хаалгаа үхүүлээд хадчив; үхүүлэн хэлэлцэж тохирсон.*

ҮХШИРЭХ 1. яг, гүнээ үйлдэх; *үхширтэл унтах;* 2. яг, ягштал, салж хагацаж чадахгүй; *үхширтлээ үнэмлэх; үхширтлээ үнэмших үхширтлээ баримтлах;* **үхширэх өвчин** (удаан ху-

гацаагаар унтах өвчин, амьсгалах, судасны ажиллагаа бараг мэдэгдэхгүй болно); 3. юмны гутаж чанараа алдах; *үхширсэн идээ; үхширсэн эд;* 4. найдлага алдах, цөхрөх; **үхширч эчих** (хүсэл бүтэлгүй цөхрөх).

ҮХЭГ 1. хээрлэн явахад бяцхан хүүхдийг агуулж тээх ба юм хум хийхэд зориулан үйлдсэн авдар мэт сав; **авдар үхэг** х о р ш.; 2. гал тогооны хэрэглэл хадгалах шүүгээ.

ҮХЭЛ үхэх үйлийн нэр; **үхэл зовол** х о р ш.; *үхэл тохиолдох; үхлийн аюул учрах; үхлийн цаг.*

ҮХЭЛДЭХ ямар нэгэн юмны төлөө их л хичээн улайж чармайх; *түүнд дурлаж үхэлдэх хэрэг юун? энэ ажилд үнэхээр үхэлдэж яваа хүн.*

ҮХЭЛТ үхсэн нь, хоролт, хорогдол; *төлийн үхэлт багасаж байгаа.*

ҮХЭР тугалмайт эвэрт, ац туурайт, хивэгчийн намын амьтан, эвэр гилгэр, сүүл урт; *үхэр мал; үхэр сүрэг; монголын үхэр; сарлаг үхэр; үг хөөцөлдөхөөр үхэр хариул* з у й р; **шуудайд хийсэн үхрийн эвэр шиг** (хүмүүсийн хоорондоо эвлэршгүй); **үхрийн бөөр шиг** (эрээвэр хураавар, олон янзын юм цугларсан); **үхэр шахах** (идшинд хэрэглэх үхрийг онцлон тэжээх, бордох); **үхэр бүрээ** (том бөгөөд бүдүүн дуутай бүрээ); **үхэр тэрэг** (үхэр хөллөж явдаг тэрэг; *үнэнээр явбал, үхэр тэргээр туулай гүйцнэ* з у й р); **үхэр буу** (их буу); **үхэр даалимба** (бүдүүн ширхэгтэй нэг зүйл даалимба); **үхэр гал** (модыг ихээр овоолж шатаасан гал): **үхэр арвай** (үслэсэн арвай); **үхэр нүд** (үхрийн нүд); ☆ **үхэр шүлхий** у р г а м а л (өндөр нь дөчин сантиметр орчим хүртэл бий, өнгө хар ногоон, хатсан цагтаа шаравтар, амт гашуун бөгөөд эхүүн, үнэр хатан нялуун, үрийн өнгө бор, болоод хуурсны хэлбэртэй, ногоон цагт нь хонь ямаа бага сага, иднэ, ихээхэн идвэл шээс хаагдах хор бий, хатсан цагт тэмээ, хонь ямаа иднэ, зарим газар өмхий өвс ч гэнэ); **үхрийн хэл** у р г а м а л (хээр газар бут бутаар ургах, навч нарийн болоод урт нь нэг сөөм илүү, навчинд соёо бий, ишгүй нэгэн зүйл ногооны нэр, болгож иднэ); **үхэр гоньд** у р г а м а л (гол горхины эрэг нуга газар ургадаг, шүхэр цэцгийн язгуурын ургамал, цэцэг нь жижиг бөгөөд цагаан); **үхэр дэгд** у р г а м а л (ойн хаяа, шугуйгаар голлож ургана, навч том бөгөөд гонзгой далбагар, хөх цэцэгтэй дэгдийн язгуурын ургамал, навч нь хатахдаа цайна); **үхэр бөлжиргөнө** у р г а м а л (өнгө улаан, амт амтайхан нэг зүйл жимсгэнэ); **үхэр харгана** у р г а м а л (харганын нэг зүйл, элстэй газар ургана, өндөр нь хоёр метр орчим бий, язгуурт хожуултай, модны хальс гялгар цайвар шар, цэцэг нь шар ногоон, цэцэг навч найлзуурыг тэмээ, хонь ямаа цэцгийг иднэ); **үхэр үүргэнэ** у р г а м а л (хээр ургана, навч уртхан болоод өргөн нэг зүйл ногооны нэр, борлуулж иднэ); **үхрийн нүд** у р г а м а л (долооны модны адил модонд овооролдон ургах жимсгэнэ): **үхэр сондуу** у р г а м а л сондуу урт, үр нь хар бөгөөд буурцгийн хонгорцог адил, хонгорцгийг шулмасын сорви гэнэ); **үхрийн шүлс** (бэр цэцэг); **үхэр мэхээр** у р г а м а л (навч урт нарийн, мэхээр мэт бүдүүн үндэслэг иштэй, цагаан ягаан цэцэгтэй ургамал, ойн зах, чийгтэй нуга газар ургана); **үхэр тарна** у р г а м а л (20—30 сантиметр өндөр, нарийн урт навчтай, жижиг цагаан ягаан цэцэгтэй, олон наст ургамал); **үхэр огдой** а м ь т а н (бие томруухан, чих том, сүүл оготор, хээр нүх малтах буюу хад чулууны хонгилд оршино, нүхнийхээ амсарт өвс, чулуу зэргийн юм хурааж овоолно); **үхэр хулгана** (үхэр огдойн өөр нэр); **үхэр бөдно** а м ь т а н (бөднөөс баахан бяцхан, шийрэндээ эрхийгүй нэг зүйл бялзуухай); **үхэр хараацай** а м ь т а н (жигүүр сүүл урт, хөл богино, энгийн хараацайгаас томхон, саравчны дор ба хаданд үүр хийнэ, хавар ирж намар буцдаг нэг зүйл хараацай шувуу); **үхэр цууцаль** а м ь т а н (цууцальтай адил болоод баахан том, нэг зүйл шувуу, дуу гарах бол эрхгүй бороо орно гэдэг); **үхэр загас** а м ь т а н (амар загастай адил, өнгө хар болоод эрээн, шүд олон бөгөөд хурц нэг зүйл загас, мөрөн голд төрнө); **үхэр халиу** (далайн элжиг); **үхэр сүүл амьтан** (мөрөн голд төрне, ахиа загаснаас томхон, сүүлийн этгээд моголцог, хайрсгүй нэг зүйл загас); **үхэр цох** а м ь т а н (хальс хатуу бөгөөд жигүүртэй, толгойд эврийн адил хоёр туршуултай нэг зүйл цох хорхой); **үхэр гүрэлзгэнэ** а м ь т а н (гүрэлзгэнийн адил болоод том, өнгө ногоон, жигүүр урт, намар жиргэдэг хорхой); **үхэр зөгий** а м ь т а н (зөгийн язгуурт багтдаг үсэрхэг, том биетэй шавьж); **үхэр жил** (Дорно зүгийн зурхайн ёсны арван хоёр жилийн хоёрдугаар нь); **үхэр ин** (том чулуун тээрэм); **үхэр чулуу** (а. мөсөн урсгалын зэрэг бодисын хүчинд анхны байрнаас хөдөлсөн том чулуу; б. газрын хөрсөн дороос онцгой цухуйж гарсан том чулуу).

ҮХЭРЖИХ үхэртэй болох.

ҮХЭРЖҮҮЛЭХ үхэржихийн үйлдүүлэх хэв.

ҮХЭРЧ (ИН) үхэр маллах хүн; *үхэрчин хүү.*

ҮХЭТХИЙХ 1. муужран унах; үхэтгэн унах; 2 ш и л ж с э н өнгө царай буурч бүдгэрхэх.

ҮХЭХ 1. амьтны амь тасрах, амигүй болох; **үхэх хатах, үхэх төрөх, үхэх сэхэх** х о р ш.; *үхсэн буурын толгойгоос амьд ат айх* з ү й р; *шидийг олоод нисэхийг шахав, шидмэсээр боолгоод үхэхийг шахав* о н ь с г о; **үхэхдээ үхэр буугаа тавих** (сөнөх, мөхөх, балрах үедээ хамгийн эцсийн аргыг хэрэглэх); **үхэх сэхээ үзэх** (дийлэх, дийлэгдэхээ үзэх); **үхэн алдах, үхэх алдах, үхэх шахах** (сандарч үхэхэд шахамдах): **үхэн зүтгэх, үхэн тэмцэх, үхэн байлдах** (ихэд чармайн зүтгэх); 2. ургамал ус чийгээр тасарч ургахгүй хатах; *үхсэн мод; цэцэг үхэх;* **үхсэн газар** (а. ургамал ургахгүй болсон газар; б. ус чийггүй газар).

ҮХЭЭНЦ тэнэг, дорой байдалтай; **үхээнц дорой, үхээнц муу** х о р ш.; *үхээнц байдал гаргахгүй, сэргэлэн цовоо явах хэрэгтэй; үхээнц царайтай амьтан байна даа.*

ҮХЭЭР 1. хүүр; *үхээрийн газар; үхээрийн бузар;* 2. үхээнц дорой.

ҮХЭЭРТЭХ доройтох, үхээнц дорой царай гаргах; *би ч бүр үхээртэж орхижээ, арай ч ийм байдаггүй сан даа.*

ҮХЭЭРШИХ сүр сүлд, хүч чадал доройтож буурах шинж орох.

Ф

Ф монголын цагаан толгойн үсэг, **Ф гийгүүлэгч**, харь хэлнээс авсан үгэнд бичнэ.

ФАБРИК түүхий эдийг машинаар боловсруулах аж үйлдвэрийн газар; *цэмбэний фабрик; цаасны фабрик; гутлын фабрик; фабрикийн ажилчин.*

ФАБРИКЧ фабрикийн өзэн.

ФАКТУР явуулах бараа зүйлийн жагсаасан тодорхойлолт бүхий баримт; *барааны фактур.*

ФАКУЛЬТЕТ дээд сургуульд алив шинжлэх ухааныг хамарсан буюу түүний аль нэгэнд суралцах салбар; *Нийгмийн ухааны факультет; багш нарын факультет; физикийн факультет; факультетийн хурал.*

ФАШИЗМ пролетари ба хөдөлмөрчин олон түмний хувьсгалын хөдөлгөөнийг дарж ардчилсан ёсыг устган, бусад орныг түрэмгийлэн эзэлж, тэр орныг, үндэстнийг хүйс тэмтрэн хайр найргүй алан талах, арьс өнгөний ялгаварааар дээрэнгүйлэх, юунаас ч буцахгүй халдан довтлох харгис хатуу дэглэмийг тогтоох эзэрхэг түрэмгий хөрөнгөтний илт алан талж дарангуйлан захирах засгийн хэлбэр.

ФАШИСТ 1. фашизмыг дагагч, фашизмын суртлыг дагагч хэрцгий харгис этгээд; 2 фашизмын, *фашист дэглэм тогтоох.*

ФЕЛЬДМАРШАЛ зарим гадаад улсын цэргийн дээд тушаал

ФЕОДАЛ феодализмын үед ард түмнийг мэлжин дарлагч ноед түшмэд, *монголын хар шар феодалууд, ард түмнийг дарлан зовоож байжээ.*

ФЕОДАЛИЗМ дэлхий дээр капитализмын өмнө байсан бөгөөд үйлдвэрлэлийн хэрэгслийг бүрэн, албат боолчуудын хөрөнгийг бүрэн биш эзэмшин, аймаг, хушуу, орон нутагтаа засгийн эрхийг барьж байсан төрийн байгуулал.

ФЕРМ нэгдэл, сангийн аж ахуйд, хөдөө аж ахуйн алив нэг салбарыг дагнаж эрхэлсэн хэсэг; *сүүний ферм; гахайн ферм, фермийн тоо бүртгэгч.*

ФЕСТИВАЛЬ их наадам; *Дэлхийн залуучууд-оюутны фестиваль; фестивалийн нээлт.*

ФИЗИК бодисын ахуй чадал, тогтоц, түүний хөдлөх ба хувилах хэлбэр, сав байгалийн үзэгдлүүдийн нийт зүй тогтоолыг судлах байгалийн ухааны үндсэн шинжлэх ухаан; бодис зүй; *онолын физик; атомын физик; физикийн ухааны дэд эрдэмтэн; физикийн лаборатори; тоо-физикийн багш.*

ФИЗИКЧ физикийн мэрэгжилтэн.

ФИЗИОЛОГИ бие махбодын үйл ажиллагааг судлах ухаан; *хүний физиологи; ургамлын физиологи.*

ФИЗИОЛОГИЧ физиологид мэрэгжсэн хүн.

ФИЛОСОФИ гүн ухаан; *философийн шинжлэлт өгөх; философийн багш.*

ФИЛОСОФИЧ гүн ухааНч, философид мэрэгжсэн хүн.

ФОНД бэлтгэл, нөөц, хөмрөг, хуримтлал; *цалингийн фонд; тэтгэврийн фонд.*

ФОНЕМ авиалбар; *эгшиг фонем; гийгүүлэгч фонем;* **фонем судлал** (авиалбарын тухай судлах ухаан).

ФОТО 1. гэрэл зураг; 2. гэрэл зургаг холбогдолтой юм; *фото зураг; фото зургийн цаас; фото зургийн аппарат.*

ФОСФОР хялбар гэрэлтдэг бөгөөд харанхуйд сүүмэлзэн харагддаг химийн махбод; зарим чулуулаг, амьтан, амьтны яс, ургамлын нэнхмэл тэргүүтэнд байна.

ФРОНТ 1. дайсны эсрэг цэргийн байрласан газар; *фронтын шугам*; 2. нэгэн жанжны захиргаанд байгаа хэд хэдэн арми, эсэргүүцэл этгээдтэй дайтаж байгаа район; *Баруун фронт; Ленинградын фронт.*

ФУНТ Орос хэмжүүрийн нэгж, 409,5 грамм болно.

ФҮНТҮҮЗ төмсний гурилаар хийсэн **татмал**; *фунтүүзтэй хоол; фунтүүзтэй хуурга.*

Х

Х үсэг Х авиа.

ХАА I дал, бугалаг, богтос, арван хавирганы хамт байгаа хэсгийн нэр; *хонины хаа; хаа гуяар нь эвдээрэй.*

ХАА II тэмээ, үхрийг зандахад хэрэглэх аялга; *хаа хүүе! хүүе хаа!, хаа хаа!.*

ХАА III хаана, хамигаа, ямар газар, аль газар гэж асуух үг; *миний ном хаа байна; таны гэр хаа вэ? үүнийг хаа тавих вэ? тэр хаа холдох ажээ.*

ХАА IV газар сайгүй, энд тэндгүй; аль ч газар, газар бүр, хаяагүй; *хаа газар ийм явдал байдаг л юм; хаа хаагүй адилхан; хаа хаагүй элбэг; хаа хаагүй ховор; хаа ч өөрцгүй.*

ХААГДАЛ хаагдах үйлийн нэр; **боогдол хаагдал** хор ш..

ХААГДАХ хаахын үйлдэгдэх хэв, боогдох, хашигдах, хоригдох; *усанд хаагдах; зам хаагдах.*

ХААГЧ алив хаадаг юм, боогч; *цорго хаагч; хаалт;* **албан хаагч** (албан үүрэг гүйцэтгэгч; *цэргийн албан хаагч; албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх).*

ХААДАЙ сая төрсөн ингэний бөгсийг салхи хүйтнээс хамгаалах нэмнээ; *эсгий хаадай.*

ХААДАЙЛАХ хаадайгаар хаах.

ХААДАЙХ хаадгар болох, таадайх.

ХААДАС I: **хаадас хаадас хийх** хаадгар юмны байн байн хөдлөх.

ХААДАС II хаалт, халх.

ХААДАЛЗАХ хаадгар юмны хаадас хаадас хийх.

ХААДГА: хаадга хаадга хийх хаадгар юмны үргэлжлэн хөдлөх.

ХААДГАНАХ хаадгар юмны хаадга хаадга хийх.

ХААДГАР паадгар, таадгар.

ХААЖ яр шархны давхарлан тогтох хогжруу.

ХААЖТАХ хааж тогтох, хааж гарах.

ХААЛГА 1. хашаа хороо, гэр байшинд орох гарах үүд; *хашааны хаалга; байшингийн хаалга; хэрмийн хаалга;* 2. спортын наадмын бөмбөгийг оруулах дээгүүрээ хөндөлтэй хоёр шон; 3. ямар нэгэн онцгой үйл явдалд зориулсан гулдан үүд; *үндсэн хуулийн хаалга;* **явган хаалга** (унаагүй хүн орж гарах жижиг хаалга).

ХААЛГАХ 1. хаахын үйлдүүлэх хэв; *үүд хаалгах; албан хаалгах;* 2. хаагдах.

ХААЛГАЧ хаалга үүдийг сахин харгалзах хүн; *зочид буудлын хаалгач; хаанаасаа хаалгач нь* сэцэн.

ХААЛТ 1. хориул, халхавч; **хаалт боолт** хор ш.; *усны хаалт;* 2. боомт, саад; 3. цэг цэгллэл болон тоо бодлогын ухаанд хэрэглэх тэмдэг; *их хаалт; дунд хаалт; бага хаалт.*

ХААЛТТАЙ 1. хаалт бүхий, хаасан нь; *хаалттай үүд;* 2. нийтийн биш, нууц; *хаалттай хурал; хаалттай дэлгүүр.*

ХААН 1. феодализмын үед үе улиран залгамжилж улс, аймгийн эрхийг ганцаараа эзэрхэгч эзэн; **хаан эзэн** хор ш.; *хаан төр; хаан засаг; хааныг аргадахаар хаалгачий нь аргад* зүйр; *хааны алба халаатай, эзний алба ээлжтэй* зүйр; **хаан ширээ** (хааны төрийн суудал); **хаан ширээнд суух** (хаан суух); **хаан суух** (хааны хойчийг залгамжлах); **хаан хүү, хаан хөвгүүн** (хааны ор залгамжлуулахаар

нэр цохолсон хөвгүүн); 2. эзэн; *хар гэртээ хаан, бор гэртээ богд* з ү й р; **хааны бугуйвч** (нэг зүйл хээ); **хаан авлах** (өвөл авлах).

ХААНА хаа; *нөгөө тарьсан жимс чинь хаана байна вэ?*

ХААНААС I аль зүгээс, аль газраас гэж асуух үг; *хаанаас ирэв? хаанаас хаа хүртэл гүйх юм бэ?* **хаа хаанаасаа** (аль аль талаасаа *хаа хаанаасаа л туслах хэрэгтэй).*

ХААНААС II яалаа гэж гэсэн татгалзан эсэргүүцэж хэлэх аялга; *хаанаас даа! би яалаа гэж чамайг тэгж муу хэлэх юм билээ.*

ХААНАХЬ хаана орших, хаана бий; *хаанахь газрын хэн гэгч бол?*

ХААНТ хаан бүхий; *хаант улс; хаант ёс;* **хаант засаг** (феодализмын үед улсыг жолоодох эзэрхэг харгис ёс, үүнд үе улиран залгамжлагч хаан нь улсын эрхийг ганцаараа барина).

ХААХ 1. онгорхой, нээлттэй зүйлийг дарж битүүлэх; *үүд хаах; цонх хаах; шүүгээ хаах;* **дэлгүүр хаах** (худалдаа хийхгүй болох); 2. явах, хөдлөхийг боож зогсоох; *ус хаах; зам хаах;* **ам хаах** (юмыг хийсэн нэр зүүж ам таглах); **хурал хаах** (хурлын үйл ажиллагааг төгсгөх; *хурал хааж үг хэлэв*); **алба хаах** (албан үүрэг гүйцэтгэх; *цэргийн албан хаах; өртөөний албан хаах*); **өр хаах** (өр таглах).

ХААХАЙХ хаахгар болох.

ХААХАЛЗАХ 1. хаахгар юмны хаахас хаахас хөдлөх; 2. цээжээ хөдөлгөж дээрэнгүй зан байдал гаргах; *хаахалзсан хаашаа амьтан бэ.*

ХААХАЛЗУУЛАХ хаахалзахын үйлдүүлэх хэв; *цээжээ хаахалзуулах.*

ХААХАС: хаахас хаахас хийх хаахгар юмны байн байн хөдлөх.

ХААХГА: хаахга хаахга хийх хаахгар юмны үргэлжлэн хөдлөх.

ХААХГАНАХ хаахгар юмны хаахга хаахга хөдлөх.

ХААХГАНУУЛАХ хаахганахын үйлдүүлэх хэв.

ХААХГАР ханхар цээжтэй, бие бялдар том; *хаахгар сайхан эр.*

ХААЦ халхавч, халх, бооц, хориул; *усны хаац; салхины хаац.*

ХААЦАЙЛАХ өмгөөлөх, хамгаалах, өмөөрөх, хаах, халхлах; *нөхрөө хаацайлах; танил талаа хаацайлах; салхи хаацайлах.*

ХААЦАЙЛУУЛАХ хаацайлахын үйлдүүлэх хэв.

ХААЧИХ хаа очих; *одоо хоёул хаачих вэ? чи хаачих гэж байна?*

ХААЧУУЛАХ хаачихын үйлдүүлэх хэв, хаа очуулах; *чи намайг хаачуулах гэсэн юм бэ?*

ХААШ 1. ямар газар, аль чигт гэж асуух үг; *чи хаашаа явах вэ?* **хааш хаашаа** (урт өргөн тийшээ, аль аль тийшээ); 2. ямар; *хаашаа янзын хүн бэ;* 3. болзоошгүй, болзошгүй; *хааш хэрэг гарвал намайг дуудаарай; намайг хааш хэрэг хүн гэж битгий бод;* **хааш яаш** (а. болгоомжгүй, хамаагүй; *энэ хэргийг хааш яаш үзэж болохгүй;* б. муу, цалгар назгай; *тэр чинь хааш яаш хүн шүү*); **хааш болович** (ямар болович, юу болович).

ХААЯА заримдаа, зарим нэгэн цагт; *үргэлж биш хааяа; хааяа ирэх; хааяа хааяа ийм явдал гардаг.*

ХААЯАГҮЙ газар сайгүй, энд тэндгүй, газар бүхнээ, газар бүр; *мал хааяагүй сайн таргалжээ.*

ХАВ I бах, ид бах; *хавтай сайхан байдаг билээ; хавтай чадалтай эр.*

ХАВ II бяцхан биетэй, богино хоншоортой, зөөлөн үстэй нохой; *арслангийн өвдөөс хав хуцахтай адил* з ү й р; **хав загас** а м ь т а н (далайн нохойн язгуур, сэлбүүр хөлтэй, сүүгээр бойжигч амьтан).

ХАВ III хүч нэмэгдүүлэх үг; **хав хар** (тас хар); **хав хатуу** (маш хатуу); **хав харанхуй** (маш харанхуй).

ХАВААС хавж оёсон оёдол; *дээлийн хавааас.*

ХАВАГНАХ 1. хавантай болох, хаван суух; 2. хавж оёсон юм энд тэндээ үрчийх, тумбан болох; *дээлийн дотор нь татаад өнгө нь хавагнаж орхижээ.*

ХАВАГНУУЛАХ хавагнахын үйлдүүлэх хэв.

ХАВАН I нэхдэс, эрхтэн дотор шингэн зүйл, нэвчдэс хуралдсаны улмаас бий болох хавдар; *хөлийн хаван.*

ХАВАН II их азраган гахай.

ХАВАН III х у у ч и р с а н ноёдын хиа нарын дарга.

ХАВАН IV хавж оёсон юмны хунирч үрчийсний нь.

ХАВАННАХ хавагнах.

ХАВАНТАХ хавагнах, хаван тогтох.

ХАВАР сарны зурхайн ёсны нэг, хоёр, гуравдугаар гурван сар; нарны зурхайн хоёрдугаар сарын дундчаас тавдугаар сарын дунд хүртлэх үе, өвлийн дараа ирэх улирал; *хавар цаг; хавар хатуу, намар баян;* **хаврын тэнгэр шиг** (олон ааштай); **хаврын улирал** (хаврын гурван сар); **хаврын үүр орох** (сарны зурхайн ёсны хорин дөрвөн улирлын нэг, нарны зурхайн хоёрдугаар сарын эхний арав хоногт тохиолдоно); **хаврын хагас дунд** (сарны зурхайн ёсны хорин дөрвөн улирлын нэг, хаврын өдөр шөнө тэнцэх хугацаа, нарны зурхайн ёсны гуравдугаар сарын хорины орчим тохиолдоно): **хаврын тарилга** (хаврын тариа тарих ажил); **хаврын цэцэг** у р г а м а л (модны навч, иш жүрүртэй адил, өнгө цагаан, зургаан хэлтэстэй, тоорцог шар, үнэр маш сайхан, навчийг хатааж шатаана).

ХАВАРЖАА (Н) хавар нутаглах газар; *манайхыг хаваржаандаа байхад...* ?

ХАВАРЖААЛАХ хаваржаандаа буух.

ХАВАРЖИН хаврын туршид; *хаваржин салхилав.*

ХАВАРЖИХ нутаглаж хаврын улирлыг өнгөрөөх; *тавтай сайхан хаваржиж байна уу?*

ХАВАРЖУУЛАХ хаваржихын үйлдүүлэх хэв.

ХАВАРШИХ хаврын шинжтэй болох; *энэ жил эрт хаваршиж байа.*

ХАВАРШУУЛАХ хаваршихын үйлдүүлэх хэв.

ХАВАРЧ: хаварч бялзуухай далан хэлт чогчого.

ХАВАХ 1. давхар юмыг хол хол нэвт оёх; *хөнжил хавах; дээл хавах;* 2. ш и л ж с э н юманд туссан сум зэрэг юм арьсны доогуур хөндийлөн явж гарах; *хавж орсон өргөс.*

ХАВГҮЙ 1. тавгүй, тохигүй; *өнөөдөр тун хавгүй өдөр байна;* 2. эвгүй, үзэмжгүй, аягүй; *эв хавгүй ширээ.*

ХАВДААХ хавдахад хүргүүлэх, хавдуулах.

ХАВДАР бие махбодын нэхдэс дотор хөөнгөрөн хөөж өвчинт шинэ юм ургах; *хорт хавдар.*

ХАВДАХ хавдар бий болох, өвчнөөр хөөж томрох; *хацар чинь хавдаж орхисон байна.*

ХАВЖИГНАХ I дагжиж ам шүд салгалан хөдлөх; *шүд хавжигнах; хавжигнатал чичрэх.*

ХАВЖИГНАХ II аманцар ярих; *хавжигнасан сүрхий хэл амтай хүн.*

ХАВЖИГНУУЛАХ хавжигнахын үйлдүүлэх хэв.

ХАВИАРАХ хамаарах, хамаарагдах, хамрах; *над хавиарахгүй.*

ХАВИГҮЙ ойр биш, хол, зүйргүй, тон; *хавигүй дээр; хавигүй олон; хавигүй муу.*

ХАВИЙНХИН ойр орчныхон; *энэ хавийнхин л иржээ.*

ХАВИР: хавир үтэр хийх харшлалдах, зүгээр байдаггүй; *та хоёр ямагт хавир үтэр хийж байдаг чинь юу вэ?*

ХАВИРАХ 1. үрэх, шүргэх, харшиж үрэлдэх; *тэрэгний дугуй юманд хавираад явна; шүд хавирах; шүдэнз хавирах;* 2. хутга мэсийн зүйлийг юманд үрж, нийлж хурцлах; *мах эвдэхээр хутгаа тоосгод хавирав;* 3. ш и л ж с э н хавидах, ойртох; *чиний хэлсэн чинь хавирах ч үгүй байна.*

ХАВИРГА (Н) 1. сээрнээс өвчүү хоёрын хоорондох тахир нарийн яснууд; *хариутай бол бяруутай, хавиргатай бол сүврэгтэй* з ү й р; **хавиргаар хатгах** (сүвээ, цээжний хажуугаар хатгаж өвдөх); **хавирга хадах** (хавирганы толгойг сээрнээс салгах); **хавирганы бураа, хавирганы толгой** (хавирганы сээртэй залгах бондгор үзүүр); 2. ш и л ж с э н хажуу тал; **уулын хавирга** (уулын хажуугийн хэлбэрүү газар); **тоосгыг хавиргаар нь өрөх** (тоосгыг хажуугаар нь өрөх): **хавирга нуруу** (байшин барилгын ноён нурууны хажуугийн нуруу); ☆ **хавирган сар** (шинийн сар).

ХАВИРГАЛАХ 1. уулын хажуугийн хэлбэрүү газраар явах; *уул хавиргалах;* 2. ш и л ж с э н хажуу талаар хэвтэх; *хавиргалж хэвтэх;* 3. од гариг огторгуйн баруун хажуу этгээдэд гарч ирэх; *Мичид хавиргалж байх уед;* 4. мө-

чөөрхөх, эн сацуурхах, тэмцэлдэх санаа гаргах; *чи надад хавиргалсны хэрэггүй.*

ХАВИРУУЛАХ хавирахын үйлдүүлэх хэв, ойртуулах.

ХАВСАА хамсаа, хань; **хань хавсаа, бүл хавсаа** хорш..

ХАВСАЙ усаар зуурч, тосонд чанасан, уртхан дөрвөлжин хэлбэртэй боов.

ХАВСАЙДАГДАХ хавсайдахын үйлдэгдэх хэв.

ХАВСАЙДАХ элбэх, хамсах, элбэж дийлэх; *хоёр этгээдээс хавсайдаж довтлох; хавсайдаж жанчих; хавсайдаж хийх.*

ХАВСАЙДУУЛАХ 1. хавсайдахын үйлдүүлэх хэв; 2. хавсайдагдах.

ХАВСРАГАДАХ хавсраганд зүдрэх, зүдэх.

ХАВСРАГАЛАХ хавсрага тавих.

ХАВСАРГАХ хавсрах I-ийн үйлдүүлэх хэв, нэгтгэж нийлүүлэх, дагалдуулах.

ХАВСАХ 1. хавсран дэлдэх; *цан хавсах;* 2. шилжсэн хамсрах, хавсрах, хамжих, хамсах; *ажлаа хавсаж хийх.*

ХАВСРАГА I 1. хамтатгал, хавтгайгаар нь ниилүүлэх нь; 2. шилжсэн хамжаа, хамжиж ажиллах хүч; *өртөөний хавсрага;* **хавсрагын өрх** хуучирсан (өртөөний алба залгуулахад хүч хавсрахаар томилогдсон өрх).

ХАВСРАГА II хуурай шуурга; *хаврын хавсрага; хавсрага тавих.*

ХАВСРАГДАХ хавсрахын үйлдэгдэх хэв.

ХАВСРАЛТ хавсарсан, хавсаргасан юм; *илтгэлийн хавсралт; хавсралт хуудас.*

ХАВСРАХ I 1. хамтатгах, хавтгай талаар нь нийлүүлэх; *алга хавсрах; мах хавсарч хөлдөөх;* 2. бөхийн мэх, хөлийн дотор талаар нөгөө этгээдийн хөлийг гадна талаас нь цохиж хоёр хөл нь бие биеэ дайран унагаахад хүргүүлэх; *хавсран таших;* 3. шилжсэн хамтрах, хамтран үйлдэх; *хүчин хавсрах;* 4. хослон гүйцэтгэх, хоёр зүйлийн үүргийг хослон биелүүлэх; *галч хавсарсан зарлага.*

ХАВСРАХ II хуурай шуурах, үргэлжлэн хүйтнээр шуурах.

ХАВСРУУЛАХ 1. хавсрахын үйлдүүлэх хэв; 2. хавсрагдах.

ХАВТ ид хав бүхий.

ХАВТАГ 1. хавтгай; *хавтаг дээрх шүгам;* 2. хавтгай юм; **нисэх онгоцны хавтаг** (далавч).

ХАВТАЙ ид хав бүхий. *хавтай мэргэн харваач; хавтай явдалтай морь; сэтгэлд хавтай санагдав.*

ХАВТАС 1. ном дэвтэр, бичиг зэрэг юмны гадуур хавчаарлан бэхлэх зүйл; *бичгийн хавтас; хатуу хавтастай ном;* **хэргийн хавтас** (аливаа албан хэргийг агуулах гадуур хавчаар); **хавтаст хэрэг** (а. хавтастай албан хэрэг; б. хэрэгтэн этгээдийн хийсэн ялт хэргийн бүрдэл, баримт тэргүүтэнг эмхтгэсэн албан хэрэг); 2. эмээлийн модны доод талын хоёр хавтгай; *эмээлийн хавтас;* 3. самбар хаалганы нэгэн тал хавтгай; *хаалганы хавтас;* 4. яст мэлхийн биений гадуур бүрхсэн ясархаг хуяг; *мэлхийн хавтас.*

ХАВТАСЖИХ хавтастай болох, хавтсаар элбэг болох.

ХАВТАСЖУУЛАХ хавтасжихын үйлдүүлэх хэв.

ХАВТАСЛАГЧ хавтаслах үйл гүйцэтгэгч; *ном хавтаслагч.*

ХАВТАСЛАХ 1. ном дэвтэр, бичигт хавтас хийх; *ном хавтаслах;* 2. юмыг хавтсаар хавчих, агуулах, хавчих хавтас үйлдэх; *хаалга хавтаслах.*

ХАВТАСЛУУЛАХ хавтаслахын үйлдүүлэх хэв.

ХАВТАСТ яст мэлхийн өөр нэр.

ХАВТАСТАЙ хавтас бүхий; *хөх хавтастай ном авч үзэв.*

ХАВТАСХИЙХ навтасхийх, балтасхийх.

ХАВТГА голдуу хуниастай амтай, зүүх сав чимэг; *аяганы хавтга; тамхины хавтга; чимгийн хавтга.*

ХАВТГАДАХ хуучирсан банздах.

ХАВТГАЙ I 1. өө товгоргүй тэгшлэг талбар хэлбэртэй; *хавтгай газар; өвгүй хавтгай тал;* **хавтгай дөрвөлжин** (адил талтай тэгш өнцөгт); **хавтгай мод** (а. банз; б. ганц хэ, гурилын мод; в. хуучирсан жанчих банз); **хавтгай модлох** хуучирсан (а. банздах;

б. банзлах); 2. нимгэн, тэгш хэлбэртэй; *хавтгай чулуу; хавтгай гурил;* **хавтгай загас** амьтан (бие хавтгай, том нь 50 сантиметр хүрнэ, зуун мянга илүү мөхлөг түрс орхидог); **хавтгай хорхой** амьтан (а. далайн ба гол нуурын усанд оршдог, бие хавтгай хорхой: б. хүн амьтны биед орших буцаш хорхой, цагаан хорхой, утсан хорхой, цацагт хорхойг хавтгай хорхой гэнэ); **хавтгай сахал** ургамал (хуучин нутагт ургана, олс мэт хэлтэстэй, өнгө цагаавтар, сөөхий гуталд давхарлаж өмсдөг өвс); 2. шилжсэн газар бүхнээ, газар сайгүй, үргэлж, энд тэндгүй; *энэ явдлын тухай хавтгай ярих болов.*

ХАВТГАЙ II амьтан тэмээн гөрөөс, зэрлэг тэмээ.

ХАВТГАЙДАХ 1. хэтэрхий хавтгай болох; 2. банздах, хавтгай модлох.

ХАВТГАЙДУУЛАХ хавтгайдахын үйлдүүлэх хэв.

ХАВТГАЙЛАХ хавтгай болгох; *хоолны гурил элдэж хавтгайлах.*

ХАВТГАЙЛУУЛАХ хавтгайлахын үйлдүүлэх хэв.

ХАВТГАЙРАХ 1. хавтгай болох; 2. шилжсэн нийтэд дэлгэрч түгэх, дэлгэрэнгүй болох; *энэ явдал нийтэд хавтгайрч байна.*

ХАВТГАЙРУУЛАХ хавтгайрахын үйлдүүлэх хэв.

ХАВТГАЛАХ хавтганд агуулах, хавтга зүүх.

ХАВТГАЛЖ амьтан бие асар том биш, толгой дээрээ өвөг бий, урт нь 36 сантиметр хүртэл, нисэхдээ хурдан, хөлдөө дөрвөн хуруутай, хорхой шавьж зэргийн жижиг амьтныг иддэг, намаг нойтон газарт байдаг шувуу.

ХАВТГАХ хавдахын үйлдүүлэх хэв, хавдуулах.

ХАВУУЛАХ хавахын үйлдүүлэх хэв.

ХАВХ орсон амьтны хөлий нь хавчин, явж чадахгүй болгох агнуурын хэрэгсэл; *тарваганы хавх; оготны хавх;* **хавх тавих** (хавх зүүх); **хавх зүүх** (ан амьтныг барихаар хавх бэлдэж тавих); **хавхны гар** (хавхны нуруу хамхих төмөр); **хавхны илбээс, хавхны улавч** (хавх зүүхэд дор нь тавих дэвсгэр); **хавхны нуруу, хавхны хуц, хавхны цамхаг** (хавхны хавчих хоёр төмөр); **хавхны тэвх** (хавхны нуруг хөших мод); **хавхны таваг, хавхны ул** (хавхны доодохь цагариг төмөр); **хавхны чирүүл** (хавханд чирэх юм).

ХАВХААС хавхаг.

ХАВХАГ таг, таглаа, нээлхий, хавхаас; *авдрын хавхаг; тогооны хавхаг; данхны хавхаг.*

ХАВХАГЛАХ 1. хавхгийг тавих, хавхгаар таглах; *бэхний савыг хавхаглах;* 2. шилжсэн юмыг харамлаж хайрлан буцдад тавьж өгөхгүй эзэмшин дарах, нуух; *юмаа хий хавхаглаж дараад л байх юм, хэзээ ч өмсөх эдлэх юм бол доо, мэдэхгүй.*

ХАВХАГЛУУЛАХ хавхаглахын үйлдүүлэх хэв.

ХАВХДАХ хавхаар барих.

ХАВХДУУЛАХ хавхдахын үйлдүүлэх хэв.

ХАВХЛАГА хий, шингэн, уур зэрэг зүйлийг хаах зорилгоор аливаа механизмд хийсэн хэрэгсэл.

ХАВЦАЛ уулын бэрх цухал, гүн жалга амсартай боомт газар; *хадан хавцал; хясаа хавцал; гүн хавцал.*

ХАВЦГАЙ 1. элгэн хад, эгц өндөр, том хад; *дуут хавцгай;* 2. уул хадны бэрх сархиаг, цухал хавцал, хад ус хавчсан газар.

ХАВЧ амьтан цэнгэг ус, далайд амьдрах, эвэрлэг ясан хуяг бүрхэвчтэй, толгойн орчинд зуух хөлтэй, голио гэдэстэй нэг зүйл загас.

ХАВЧААР 1. хавчуур, хавчих хэрэгсэл; *салын хавчаар;* 2. хуучирсан урьдын цагт эхнэр хүний үсийг хавчих хэрэгсэл; *мөнгөн хавчаар; хулсан хавчаар;* 3. хоёр юмны завсарт хавчин барьж оёх зурвас зүйл; *гутлын хавчаар.*

ХАВЧААРЛАХ юманд хавчаар барьж оёх, хавчаар хийх.

ХАВЧААРЛУУЛАХ хавчаарлахын үйлдүүлэх хэв.

ХАВЧААХАЙ I 1. бүдүүвтэр хийцтэй, элэг тэвхгүй нум; 2. чавх; *хулсан хавчаахай.*

ХАВЧААХАЙ II хавч хорхойн өөр нэр.

ХАВЧГАР 1. хоёр этгээдээс шахагдсан мэт хэлбэртэй нимгэндүү, хавчиг; *хавчгар толгой;* 2. туранхай яданги; *хавчгар хүчтэй байна.*

ХАВЧГАРДАХ хэтэрхий хавчгар болох.

ХАВЧГАРДУУЛАХ хавчгардахын үйлдүүлэх хэв.

ХАВЧИГ 1. хавчгар, хоёр этгээдээс шахагдсан мэт дүрстэй; *хавчиг толгойтой бөөрөнхий биш хавчиг;* **хавчиг үүрэг** х у у ч и р с а н (урьдын бадарчны хэрэн явахдаа үүрч байсан, бургасаар хийсэн үүрэг); 2. өргөн, уудам, дэлгэр биш, давчуу, явцуу; *уулын хавчиг ам; хавчиг өрөө тасалгаа;* 3. дүгрэг биш, зууван хэлбэртэй модон торх сав; *хавчигтай ус;* 4. хавчаар; 5. ш и л ж с э н малын нас биеийн гүйцэд биш, гүйцэж чадаагүй, дутуу; **хавчиг соёолон** (их насанд хүрч чадаагүй, соёолон гийн дээдэх нас): 6. ш и л ж с э н хаваршиж төрсөн ишиг, хурга; хавчрай ч гэдэг.

ХАВЧИГДАЛ хавчигдах үйлийн нэр; *хавчигдал багатай байхын төлөө тэмцэх.*

ХАВЧИГДАЛГҮЙ хавчигдах, боогдох юмгүй, чөлөөтэй тайван, амгалан.

ХАВЧИГДАХ 1. хавчихын үйлдэгдэх хэв; 2. ш и л ж с э н боогдох, гачигдах, хяхагдах; *аргагүйн эрхэнд хавчигдах; өрд хавчигдах;* 3. ганцаардах, хамгаалах этгээдгүй ганцдах; *би тун их хавчигдаж байв;*

ХАВЧИГХАН арай хавчиг, нилээд хавчиг.

ХАВЧИЙЛГАХ хавчийхын үйлдүүлэх хэв; хавчгар болох.

ХАВЧИЙХ хавчгар болох.

ХАВЧИЛ хавцал.

ХАВЧИЛТ хавчлага.

ХАВЧИХ 1. шахах, хоёр этгээдээс шахаж дарах; *бахиар хавчих; хавчаараар хавчих; гутал хавчих;* 2. ш и л ж с э н хяхах, үзэн ядах, гадуурхах, ад үзэж боогдуулах; *арьсны үзлээр гадуурхан хавчих харгис бодлоготой этгээд байжээ; хавчиж боогдуулах; албадан хавчих; сүрдүүлэн хавчих; шүүмжлэлийг хавчих.*

ХАВЧЛАГА 1. хавчих нь; **хавчлага дарах** (загас агнах нэг арга); 2. ш и л ж с э н албадлага, хүч түрлэг; **албадлага хавчлага** х о р ш.; *хавчлагаар нутагт нь суулгасан байв.*

ХАВЧЛАГАГҮЙ хавчих юмгүй, эрхээрээ; *би ажлаа ямар ч хавчлагагүй хийдэг юм.*

ХАВЧЛАГАТАЙ эрх дураар биш, бусдын шахалт шаардлага, хавчилттай.

ХАВЧЛАХ байн байн хавчих.

ХАВЧРАЙ 1. хоног сар гүйцээгүй төрсөн, малын төл; 2. адууны хавчиг соёолон.

ХАВЧУУЛАГДАХ хавчуулахын үйлдэгдэх хэв.

ХАВЧУУЛАХ 1. хавчихын үйлдүүлэх хэв; 2. хавчигдах; *сугадаа хавчуулах;* **толгой хавчуулах** (бусдын эрхшээлд багтан ядах; *би тэднийд түр зуур толгой хавчуулж байна*); **хормойдоо салхи хавчуулах** (дэмий сэлгүүцэх).

ХАВЧУУР 1. хавчих зэвсэг, хавчаар; *бичгийн хавчуур;* 2. олны дотор арай багталцаж байх нь; *хавчуур болж явах.*

ХАВШАА үглээ, яншаа.

ХАВШИЙЛГАХ хавшийхын үйлдүүлэх хэв.

ХАВШИЙХ хавчийх, навшийх.

ХАВШИХ I усан дээрх ялаа хорхой мэтийг загас шүүрэх.

ХАВШИХ II 1. олны муулах, нийтээр шагшин шүүмжлэн хэлэлцэх; 2. үглэж янших.

ХАВЬ 1. орчим, ойр, ойролцоо, орчин тойронд; **ойр хавь** х о р ш.; тэр хавийн айлуудад *орж үзэв; хавь нутгийн хүн; энэ хавьд тийм хүнгүй;* 2. ш и л ж с э н орчимд биш, ойролцоо биш; *ийм хүчтэй салхи хавьд болоогүй.*

ХАВЬС 1. хавирга; *богино хавьс;* **хавьсан сар** (хавирган сар); 2. ялтас, хайрс; *хуягийн хавьс; жанчны хавьс.*

ХАВЬСГАНА у р г а м а л хяр хадтай газар ургана, өндөр нь 20 орчим сантиметр, хавтгай уртуулаг навчтай, гашуувтар амттай, сүү мэт цагаан шүүстэй ургамал.

ХАВЬСЛАХ 1. юманд хавьс хийх; 2. ш и л ж с э н нар, сарны хоёр этгээдэд туяа тусах; *нар хавьслах; сар хавьслах.*

ХАВЬТААХ хавьдахад хүргүүлэх, хавьтуулах.

ХАВЬТАХ 1. хавьд очих, ойр очих, ойртох; *хавьтаж ойртох; хавьтахад бэрхтэй;* 2. ш и л ж с э н дотнолон ойртох.

ХАВЬТАХГҮЙ хавьтах аргагүй, ойртох нь хол; *хавьтахгүй их; хавьтахгүй хол.*

ХАВЬТУУЛАХ хавьтахын үйлдүүлэх хэв; *хавьтуулахгүй хөөх.*

ХАВЬЦАА ойролцоо, хавьд; *Хайрхан уулын хавьцаа хэдэн адуу байна билээ.*

ХАВЬЦАГ хоёр гуяны нийлэлтийн газар.

ХАВЬЦАХ ойртож очих, ойр очих.

ХАВЬЦАХГҮЙ ойртож очихгүй.

ХАВЬЧАА 1. үглээ яншаа, огт дугуй суудаггүй; 2. амьтны тогтворгүй, хөдөлгөөнтэй.

ХАВЬЧИХ 1. үглэн яншиж ярих; 2. тогтворгүй тэлчлэн хөдлөх.

ХАВЬЧУУЛАХ хавьчихын үйлдүүлэх хэв.

ХАГ I ямар нэг юман дээгүүр тогтох зүйл; **чулууны хаг** (хад чулууны гадуур бүрхэж тогтсон зүйл); **толгойн хаг** (арьсны өнгөнцөр хөрснөөс хууран гарах зүйл); **шүдний хаг** (шүдэн дээр тогтох чулуурхаг хөгц); **төмрийн хаг** (төмрийг хүдрээс хайлуулж авахад гарах хатуу зүйл).

ХАГ II малын төрөхөд гарах хальс.

ХАГА хүч нэмэгдүүлэх үг; *хага цохих; хага зүсэх; хага татах;* **шүд хага таших** (маш хүйтэн юманд шүд янгинах).

ХАГААС загас барих дэгээний үзүүр.

ХАГАДАС I хагачсан мод, жиргэж хагалсан түлээ.

ХАГАДАС II загасны яс.

ХАГАЛАХ 1. юмыг эвдлэх, хэмхлэх; **толгой дээр нь цахлур хагалах** (аргагүй хүч дийлж явах); 2. иртэй юмаар цохиж цуулах; *түлээ хагалах;* 3. иртэй юманд огтлох, зүсэх; *шилэнд гараа хагалах;* 4. тариалан тарихын тулхөрсийг урвуулан сэвсийлгэх; *трактороор газар хагалах; анжсаар хагалсан газар;* 5. ширжсэн үс, дэл зэргийг хоёр тийш нь хувааж ярах, самнах; **үсээ хагалах** хуучирсан (эхнэр болох); 6. ширжсэн тэмцээн зөрөлдөөн бүхий хэрэг заргыг таслах, туурвих, шийдвэрлэн шийтгэх; *зарга хагалах.*

ХАГАЛБАР 1. шинэ тарьсан тариалан; *хагалбар тариалан;* 2. усны хоёр тийш салж урсах газар; *усны хагалбар;* 3. үс, дэл мэтийн хоёр тийш хагаран ярсан газар; **хагалбар дэл** (хоёр тийшээ тэгш унжсан дэл).

ХАГАЛБАРЛАХ хагалбар гаргах, хагалах; *газар хагалбарлах.*

ХАГАЛБАРЛУУЛАХ хагалбарлахын үйлдүүлэх хэв.

ХАГАЛАГДАХ хагалахын үйлдэгдэх хэв.

ХАГАЛАЛТ хагалсан нь.

ХАГАЛГАА хагалах үйлийн нэр; *их хагалгаа; бага хагалгаа.*

ХАГАЛГАХ хагалуулах.

ХАГАЛУУЛАХ 1. хагалахын үйлдүүлэх хэв; 2. хагалагдах.

ХАГАРАЛ 1. хагарах үйлийн нэр; 2. эвдрэл, эвгүй, найрамдалгүй болох нь; **эвдрэл хагарал** хорш.; *хагарал гарах.*

ХАГАРАХ 1. эвдрэх, хэмхрэх; *шил хагарах; шаазан хагарах;* 2. язрах, эмтэж цуурах, ан амсар гарах; *газар хагарах; уруул хагарах; зүрх хагарах шахав;* 3. шилжсэн эв эвдрэх, эвгүй болох, муудалцах; **түнжин хагарах** (эв муутай болох, хэрэлдэх): ☆ **нүүр хагарах** (олны өмнө үг хэлэх, дуулах зэрэгт ичиж зовохгүй болох).

ХАГАРХАЙ 1. хагарсан юм; *хагархай ваар; хагархай цонх;* **хагархай хэнгэрэг шиг** (дуулсан сонсоноо эрээ цээргүй чалчих, ярих зантай); 2. хэлтэрхий; *шилний хагархайд гараа зүсч орхив;* 3. хагалсан, ам, нүхтэй, ангархай; **хагархай өмд** (бяцхан хүүхдэд өмсгөх, салтаа нь битүү биш өмд); **хагархай хушга** ургамал (хушганы модонд ургана, хушганы адил бөгөөд бяцхан уртхан, хальс зузаан, цөмөө цөөн нэг зүйл самар).

ХАГАС 1. бүтэн юмны нэгэн тал нь; *зууны хагас тавь; хагас хувийг эзлэх; цаг гурав хагас болов; цаг хагас; хагас жил; хагас өдөр; хагас зуун;* 2. бүрэн бүтэн биш, дутуу заримдаг; **хагас заримдаг, хагас дутуу, хагас хугас** хорш.; *ихэнх хагас нь алга;* **хагас дамжуулагч** (цахилгаан муу дамжуулдаг мод зэрэг зүйл); **хагас арал** (гурван талаас тэнгэсээр хүрээлэгдэж, нэг тал нь эх хуурай газартайгаа үргэлж газар); **хагас колони** (гадна талаас үзэхэд тусгаар мэт боловч улс төр, эдийн засгийн хувьд аль нэг хөрөнгөтөн гүрний нөлөөнд бий улс).

ХАГАСДАХ хагасын учир тохиромжгүй болох.

ХАГАСЛАГДАХ хагаслахын үйлдэгдэх хэв.

ХАГАСЛАХ 1. дундуур нь хуваах, хоёр хагас болгох; 2. хагас хугас, заримдаг дутуу болгох; *үүнийг хагаслаж орхиод яах вэ, нэг*

мөсөн гүйцээсэн нь дээр; 3. өдөр цагийн нэгэн хагаст хүрэх; *шөнө хагаслан мордох.*

ХАГАСЛУУЛАХ 1. хагаслахын үйлдүүлэх хэв; 2. хагаслагдах.

ХАГАЦААХ хагацуулах, хагацахад хүргүүлэх.

ХАГАЦАЛ хагацах үйлийн нэр, ангижрах нь; *хагацал ирэх; хагацал дайрах.*

ХАГАЦАЛДАХ хагацахын үйлдэлдэх хэв, харилцан хагацах.

ХАГАЦАЛЦАХ хагацахын үйлдэлцэх хэв, бусдын хамт хагацах.

ХАГАЦАХ бүрмөсөн салах, ангижрах; *салж хагацах; сайн нөхрөөсөө хагацав; үхлээс хагацах.*

ХАГАЦАШГҮЙ салшгүй, ангижиршгүй; *хагацашгүй сайн нөхөр.*

ХАГАЦУУЛАХ хагацахын үйлдүүлэх хэв.

ХАГАЧИГДАХ хагачихын үйлдэгдэх хэв.

ХАГАЧИХ 1. байн байн хагалах, хага хага цохих; *хагачиж хаях;* 2. нэгмөсөн хагарах, хагарч орхих; *шаазан хагачжээ.*

ХАГАЧУУЛАХ 1. хагачихын үйлдүүлэх хэв; 2. хагачигдах.

ХАГД I жил өнжиж үлдсэн өвс, хатсан өвс; **хагд ожорс** у р г а м а л (урт уяхан иштэй, намгийн, олон наст өвс).

ХАГД II: **хагд үе** 1. ясны хуурай үе; 2. хүний бугуйн үе.

ХАГДГАНАХ хагдгар, агдгар юмны түгдэгнэн хөдлөх, агдганах; **агдганан хагдганан** х о р ш.; *хагдганан инээх; хагдганан гүйх.*

ХАГДГАР нуруу, өвчүү бойцгор, агдгар.

ХАГДРАХ өвс ургамлын хагд болох.

ХАГЖ хааж.

ХАГЗАРХАЙ ханзархай.

ХАГЗЛАХ ханзлах, ханзрахад хүргүүлэх.

ХАГЗРАХ ханзрах.

ХАГЗЧИХ ханзчих.

ХАГИХ цэцэг өвчний сорвины хаг ховхорч унах.

ХАГЛАХ юмны завсар цоорхой мэтийг шавах, бөглөх.

ХАГЛИН маш нимгэн, панс мэт бараа.

ХАГСАА хагссан нь; *торхны хагсааг гаргах.*

ХАГСААМАЛ 1. хагсаасан нь; 2. хагсааж болгосон мах.

ХАГСААХ 1. хагсахын үйлдүүлэх хэв, хагсахад хүргүүлэх; 2. малд тэжээл, өвс идүүлэхгүй уяж чийрагжуулах, сойх; *морь хагсааж унах;* ☆ **мах хагсаах** (махыг халуун юман дээр хайрмаглан, шүүсий нь гадагш гаргалгүй хатаах).

ХАГСАХ I 1. мод зэрэг юмны хатаж щуумайх; 2. модон сав суулга хатаж завсар гаран шингэн юм гоожих болох; *хагссан хавчиг;* **шүд хагсах** (исгэлэн жимс мэтийг үлэмж идсэнээс болж шүд эмзэглэх); 3. ш и л ж с э н унд хоолгүй өлөн байх; *морь хагсах;* 4. хоол унд холдож дотор онхох; *дотор хагсах.*

ХАГСАХ II хагтах, хаг тогтох.

ХАГСРААХ хагсрахын үйлдүүлэх хэв; *чоно авлахаар морь хагсраах.*

ХАГСРАХ I морь малын унд тэжээл хязгаартай болж гэдэс хөнгөрөх; *хагсарсан мориор давхиж хүрэх гэж байв.*

ХАГСРАХ II боорцгийн шаралтал буцлах.

ХАГСРУУЛАХ хагсрахын үйлдүүлэх хэв, хагсраах.

ХАГСУУРАХ хагсах, хагсрах.

ХАГТААХ хагтуулах, хагтахад хүргүүлэх.

ХАГТАХ хаг тогтох, хаг суух; *толгой хагтах.*

ХАГТУУЛАХ хагтахын үйлдүүлэх хэв.

ХАГШААС үерээр хуралдсан өвс модны хаягдал.

ХАГШРАХ 1. шавхай усны агшиж хатах; 2. яр түүхий агшиж хатах.

ХАД (АН) I уул дахь асар том ургаа чулуу; **уул хад** х о р ш.; *хад асгатай газар;* **хадан хушуу** (уулын шувтрах хадан үзүүр); **хадны хайлмал** (нэгэн зүйл бодис); **хадны дууриан** (хадны цууриан); **хадан өвс** у р г а м а л (хаданд ургадаг нэгэн зүйл өвс); **хадны хүж** у р г а м а л (уул хаданд ургах хөрөөний

ир мэт хөвөөтэй уртлаг навчтай, хатан үнэртэй ургамал); **хадны болжмор** а м ь т а н (чандрын өнгө хядруу бялзуухайгаас баахан өөр, уул хадны анд үүр хийдэг болжмор); **хадны харагчин** а м ь т а н (толгой бие нь ногоовторхон, хөмсөг их, ихэд жиргэдэг нэг зүйл бялзуухайн нэр); **хадны гөрвөл** а м ь т а н (хадан хайрга газар орших нэгэн зүйл гөрвөл); **хадны мангаа** (хүүхдийг хууран айлгаж хэлэх үг); **хадны өвгөн** (хадны мангаа); **хадны хаг** (хаданд наалдаж ургасан хэг).

ХАД II у р г а м а л 1. исгэлэн амтлаг, хар хүрэн жимсгэнэтэй бут мөн жимсгэнэ нь; 2. жимсгэнийн шүүсээр нимгэн царцаан эвхэж хийх зүйл.

ХАДАА хүн амьтан явахад даахуйц болж хөлдсөн мөс, мөсөн зам.

ХАДААЛААГҮЙ хадаалж чадаагүй; *гүйцэд хадаалаагүй гол дээгүүр гарахад аюултай.*

ХАДААЛАХ хадаа тогтох; *гол хадаалах; хадаалсан мөсөн дээгүүр явах.*

ХАДААЛУУЛАХ хадаалахын үйлдүүлэх хэв.

ХАДААС (АН) I юмыг хадаж бэхлэхэд зориулж нэг талдаа шовх үзүүртэй, нөгөө талдаа хавтгай малгай тавтай, голдуу төмрөөр хийдэг хэрэгсэл; *төмөр хадаас; хулсан хадаас; хадаасаар хадах; хадаасны тав.*

ХАДААС II тоотой юмнаас дутагдвал нөхөх зорилгоор бэлтгэл болгож хийсэн илүү юм; *кубээ хадаастай хийгээрэй.*

ХАДААС III хонинд тохиолдох нэг зүйл халдварт өвчин.

ХАДААС IV у р г а м а л нарийн урт навчтай, бут бутаар ургах ургамал, цэцэг нь шар, хүрэн байна, хортой, эмнэлэгт хэрэглэнэ.

ХАДААСДАХ хадаас ихийн учир тохиромжгүй болох.

ХАДААСЛАХ хадаасаар бэхлэн хадах.

ХАДААСРАХ хадаас мэт болох; *мод хадаасрах.*

ХАДААСТАЙ 1. хадаас бүхий юм; 2. хадаас бэлтгэлтэй; 3. хадсан юм.

ХАДААСТАХ хонинд хадаас өвчин тусах.

ХАДААХ 1. *хадахад хүрүүлэх; санаандаа хадаах;* 2. цуурай гаргах; *дуу хадаах; манан хадаах.*

ХАДААШИХ сэтгэлд хоногшиж тогтох.

ХАДААШРАХ сэтгэлд хоногшиж тогтох шинж орох.

ХАДАГ хүндэтгэл, зочлолд барьж өгөх, тусгай хэлбэр маягийн мяндсан нэхмэл эд; **хадаг шудаг, хадаг самбай** х о р ш.; *баранзад хадаг; нанзад хадаг; вандан хадаг; соном хадаг; зочинд хадаг барьж өгчээ;* **хадаг тавих** х у у ч и р с а н (хүүхнийг гуйж богтлоход хадаг барих).

ХАДАМ эрд эхнэрийн, эхнэрт эрийн талын тус тусын ахлах хүмүүс; *хадам эцэг; хадам эх; хадмындаа айлчлан очих; хадам ах; хадам эгч; хадамд очих; хад сайтай үнэг бардам, хадам сайтай хүргэн бардам* з ү й р; **хадам бэргэн** (хадам ахын гэргий).

ХАДАМЛАХ охиныг хадамд өгөх, хадамдаа айлчлан очих.

ХАДАМСАГ хадамдаа элэгсэг, хадамсуу.

ХАДАМСАХ хадамдаа элэгсэглэх.

ХАДАМСУУ хадамсаг.

ХАДАР а м ь т а н цагаан зарамтай төсөөтэй загас, маш тунгалаг устай жихүүн газарт оршино.

ХАДАРГАН I мөрь малын асар хурдангүй боловч довтолсхийн явахад зоригтой тэнхлүүн.

ХАДАРГАН II 1. хадрамтгай, хадрахдаа хэцүү; 2. ш и л ж с э н идэмхий, ховдог; 3. ш и л ж с э н эвдэмтгий, сүйтгэмтгий, халтай.

ХАДАРМАГ ургаагаар өтөлж хатсан гоёо.

ХАДАРХАГ хад ихтэй, хадархуу; *хадархаг газар.*

ХАДАРХУУ 1. хадархаг; 2. хад мэт.

ХАДАХ I 1. хадаас мэтийг цохин шааж бэхлэх; *хадаасаар хадах; гутал хадах;* 2. ш и л ж с э н тээглэж үлдэх, шааж хоцрох адах; *хоолойд яс хадах;* **санаанд хадах** (санаанаас үл гарах, огт үл мартагдах); 3. юманд юм бэхлэн оёх; *товч хадах; малгайд буч хадах;* 4. ш и л ж с э н бичсэн үсгийн хажууд орчуулж бичих; *галиг үсгээр хадах.*

ХАДАХ II хадуураар цавчин огтлох; *өвс хадах; тариа хадах.*

ХАДАХ III дэгдэх цуурайтах: *дуу тэнгэрт хадах; тэнгэрт тоос хадах; манан хадах.*

ХАДАХ IV: **хавирга хадах** хавирганы толгойг сээрнээс салгах.

ХАДГАЛАГДАХ хадгалахын үйлдэгдэх хэв.

ХАДГАЛАГЧ хадгалах үүрэг бүхий хүн.

ХАДГАЛАЛТ хадгалсан байдал нь; **хадгалалт хамгаалалт** х о р ш .. .

ХАДГАЛАМЖ хадгалах газар; *хадгаламжийн касс.*

ХАДГАЛАХ агуулах, байлгах, авч байх; *агуулах газарт хадгалах; авдарт хадгалах; биедээ хадгалах.*

ХАДГАЛУУЛАХ хадгалахын үйлдүүлэх хэв, хадгалахад хүргүүлэх.

ХАДЛАН хадаж авах өвстэй газар; мөн өвс нь; *айлын хадлан; хадланд гарах; хадлан авах; хадлан хураах; хадлангийн газар; хадлангийн машин багаж хэрэгсэл.*

ХАДЛАНЖИХ хадлантай болох.

ХАДЛАНЖУУЛАХ хадланжихын үйлдүүлэх хэв.

ХАДЛАНШИХ хадлангийн шинжтэй болох.

ХАДЛАР а м ь т а н уул хаданд авирахдаа чадамгай нэг зүйл гөрөөс.

ХАДМАЛ бичиг номд өөр хэл, үсгээр хавсарган бичсэн үг тайлбар; *төвдөөр хадмал; хадмал толь;* **хадмал** үг (зүүмэл, зүүсэн, зүүж бичсэн үг).

ХАДМАЛЛАХ бичиг номын зүйлд хадмал бичих.

ХАДМАЛЛУУЛАХ хадмаллахын үйлдүүлэх хэв.

ХАДРАГДАХ хадрахын үйлдэгдэх хэв.

ХАДРАН а м ь т а н бие бага боловч ясархаг, сэлбүүр үзүүртэй нэг зүйл загас, голын усанд төрнө.

ХАДРАХ 1. зарим араатан амьтны зууж урах, шархтаах; *зэрлэг гахай соёогоор хадрах; шүдээрээ хадрах;* 2. ш и л ж с э н сүйтгэх, чирэгдүүлэх; **хаяагаа хадрах** (хаяандаа айл байгсдыг сүйтгэх); 3. хүн амьтны юм идэхдээ гүжирмэг шаламгай аашлах; *хоол хадрах;* 4. юмыг юмаар зурчин үрчин гэмтээх, эвдлэх; *хашаа хадрах; байшингийн шаврыг хадарч зурах.*

ХАДРУУЛАХ 1. хадрахын үйлдүүлэх хэв; 2. хадрагдах.

ХАДУУЛАХ хадахын үйлдүүлэх хэв.

ХАДУУЛГАХ хадуулахын үйлдүүлэх хэв.

ХАДУУН бүдүүн; **бүдүүн хадуун** х о р ш..

ХАДУУР өвс тариаг хадах зэвсэг; *өвсний хадуур; тарианы хадуур; Зөвлөлт Улсын алх хадууртай сүлд тэмдэг.*

ХАДУУРАХ 1. давхиж яваа морины ам дийлэгдэхгүй буруу тийш зулран одох; *хадуурдаг морь;* 2. ш и л ж с э н буруу зөрүү ярих, үнэн байдлаас гажиг дэмий ярих; *хадуурч ярих, хадуурч сонсох.*

ХАДУУРУУЛАХ хадуурахын үйлдүүлэх хэв.

ХАДУУХ амьтны аманд юм тээглэх; *нохойн шүдэнд яс хадуух.*

ХАЖ I 1. төмөрлөгөөр хийсэн эдлэлийн зах ирмэгийг чимэглэсэн хээ, угалз; *хажтай мөнгөн домбо; хаж гаргах;* 2. чимэглэлийн зүйлд шигтгээ суулгах тав, суурийн хүрээ; *хаж тавих.*

ХАЖ II арааган амьтныг агнах нэгэн зүйл урхи; *хаж зүүх.*

ХАЖААС хажлага.

ХАЖИГ бусадтай нийлэмж найралгүй зантай, этгээд, гаж буруу зантай, зожиг; *хажиг амьтан; хажиг этгээд зан гаргах.*

ХАЖИГЛАГДАХ хажиглахын үйлдэгдэх хэв.

ХАЖИГЛАХ хажиг зожиг зан гаргах.

ХАЖИГЛУУЛАХ 1. хажиглахын үйлдүүлэх хэв; 2. хажиглагдах.

ХАЖИЛГАЛАХ хажих, хажлага хийх, мөшгөөр хийх.

ХАЖИХ I хувцасны зүйлд хажлага тавих; *дээл хажих.*

ХАЖИХ II төмөрлөг эдлэлд хаж хийх: *алтаар нь хажих.*

ХАЖИХ III гадуурхах, хажиглах.

ХАЖЛАГА хажаас, дээл хувцасны энгэр хормой зэрэг зах этгээдийн дотоод талд барьж оёсон давхцалга; *дээлийн хажлага; хажлага тавих.*

ХАЖМАЛТ буслыгаа үхүүлж гон бие, өнчин хоцорсон; *хажмалт хүн.*

ХАЖУУ 1. нэгэн этгээд, нэгэн тал жигүүр; *биейн нэгэн хажуу; хажуу тийшээ болох;* **зүүн хажуу** (зүүн үзүүр этгээд); 2. дэргэд, шадар; *хажууд нь суух; хажуугийн айл; хажууд минь суугаа амраг минь, хамаг олны баясгалан* (дуу); **хажуу хавирга** (хажуу тал); 3. уулын хэвгий; *хажуу талын ногоо халиурч найган ганхана; тэр хажуу дээр билчиж байгаа үхэр бол...* 4. энгийн, гаднын, хөндлөнгийн; **хажуугийн хүн** (шууд холбогдохгүй хүн); 5. шилжсэн сацуу, зэрэгцээ, хооронд; *ядаж байхын хажууд, морь минь чөдөртэйгөө тэгж явчжээ;* **хажуугаар** (а. хажуу талаар; *уулын хажуугаар явах; хажуугаар хэвтэх;* б. дэргэдүүр; *чиний хажуугаар өнгөрсөн шүү;* в. сацуу, зэрэгцээ; *ярахын хажуугаар ажил гараад болдоггүй*). • **ХАЖУУГААРХИ** хажуу талаархи, дэргэдүүрхи; *хажуугаархи юмсаа татаж ав!*

ХАЖУУДХАН хажууд ойрхон; *манайх танай хажуудханд байдаг.*

ХАЖУУЛАХ I 1. хажуугаар хэвтэх; 2. бяцхан зуур хэвтэж амрах; *жаахан хажуулж байгаад босов;* 3. юм налж түших.

ХАЖУУЛАХ II хажих I, II-ын үйлдүүлэх хэв.

ХАЖУУЛАХ III хажуу газраар явах.

ХАЖУУЛДАХ 1. хажуулах, хажуугаар хэвтэх; 2. хажуу газраар явах; *хажуулдаж явах;* 3. хажуугаар болох; *хажуулдаж унах.*

ХАЖУУЛДУУЛАХ хажуулдахын үйлдүүлэх хэв.

ХАЖУУЛСХИЙХ бяцхан хажуулах; *хажуулсхийгээд явах.*

ХАЖУУЛУУЛАХ хажуулахын үйлдүүлэх хэв.

ХАЖУУЛУУШТАЙ хажуулмаар, хажуулахад тааламжтай.

ХАЖУУХАЙ маш бяцхан байдалтай юм; **эжүүхий хажуухай** хорш.

ХАЗААР морины толгойд өмсгөх амгай, зуузай, жолоо, цулбуур бүхий хэрэгсэл; **суран хазаар** (тоноггүй хазаар); **товруутай хазаар** (товгор тоногтой хазаар); **хазаарын толгой** (жолоо, цулбуургүй хазаар); **хазаарын хамар** (хазаарын хамар дээгүүр байдаг хэсэг газар); **хазаар дарах** (хазаартай морь толгойгоо хаялан хөдөлгөх); **хазаар өвс** ургамал (иш нь боловсрохдоо цагариглан, үндэснээсээ ангижирч салхинд хийсдэг өвсөрхөг ургамал).

ХАЗААРГАНА ургамал хазаар өвсний төрлийн нэгэн зүйл өвс.

ХАЗААРГҮЙ 1. хазаар байхгүй; 2. шилжсэн хорио цээргүй, дур зоргоороо; *хазааргүй морь шиг загнаж байв.*

ХАЗААРЛАГДАХ 1. хазаарлахын үйлдэгдэх хэв; 2. шилжсэн хориглогдох, боогдох.

ХАЗААРЛАХ 1. морь малын толгойд хазаар өмсгөх; *морь хазаарлах;* 2. шилжсэн хорих, хориглох; *амы нь хазаарлаж байхгүй бол болдоггүй амьтан.*

ХАЗААРЛУУЛАХ 1. хазаарлахын үйлдүүлэх хэв; 2. хазаарлагдах.

ХАЗААРТАЙ хазаар бүхий, хазаар бүхий мэт; *мөнгөн хазаартай; хоолоо түргэн идчихгүй хазаартай юм шиг байхын хэрэг юү вэ; хазаартай юм шиг дуугарч цөхсөн хачин амьтан.*

ХАЗАГДАХ хазахын үйлдэгдэх хэв.

ХАЗАЙЛГАХ хазайхын үйлдүүлэх хэв, хазайхад хүргүүлэх; **утгыг хазайлгах** (утга учрыг гажуудуулах).

ХАЗАЙХ 1. хажуу тийш ганхах, хэлбийх, таших цэх биш болох; *туг хазайх; замаас хазайх;* 2. үл дагах, ёсоор эс гүйцэтгэх; *хэлсэн үгнээс хазайх;* 3. шилжсэн ажил үйл бүтэмж муутай болох; *хазайсан дээр нь хазайлгах; заяа нь хазайх.*

ХАЗАЛЗАХ баахан хазганах, доголсхийх; **хазалзаж мижилзэх** хорш.; *зээрд морь жаахан хазалзаж явна.*

ХАЗАМТГАЙ хаздаг зантай; *хазамтгай буур.*

ХАЗАХ 1. шүдээр зуух; *шүдэндээ хазах; хаздаг морь;* **тас хазах** (хазаж таслах); 2. шавьж хорхойн хатгах; *шумуул хазах; хорхой хазах;* 3. зарим юмны зуух, хавчих; *бахь хазахгүй болжээ;* **хайч хазах** (хайч юм даахгүй хэгэх болох).

ХАЗВАЛЗАХ хазалзах.

ХАЗГАЙ 1. хэлтгий, хэвгий, тэгш биш; **хазгай хэвгий** х о р ш.; *хазгай газар;* 2. буруу, эндэлтэй; *хазгай гишгэхийг андахгүй;* 3. ташаа, зөв биш; **хазгай хузгай** х о р ш.; **хазгай хэлэх** (буруу, хэлгий хэлэх); 4. ш и л ж с э н буруу, хар, хуурмаг; *хазгай санаж явсангүй билээ.*

ХАЗГАЙДАХ хэтэрхий хазгай болох; *газар нь хазгайдаад гэрээ барьсангүй.*

ХАЗГАЙДУУ баахан хазгай, нилээд хазгай.

ХАЗГАЙДУУЛАХ хазгайдахын үйлдүүлэх хэв.

ХАЗГАЙРАХ 1. хазгай болох; 2. ш и л ж с э н гажууд болох, үл зохицох, үл нийлэх.

ХАЗГАЙРУУЛАХ хазгайрахын үйлдүүлэх хэв.

ХАЗГАЛЗАХ хазганах, хазалзах, хазвалзах.

ХАЗГАНАХ хазгар юмны үргэлжлэн хөдлөх; *хазгар азрага хазганаж явав.*

ХАЗГАНУУЛАХ хазганахын үйлдүүлэх хэв.

ХАЗГАР I доголон, хөл гэмтэй учир цэх явж үл чадах; *хазгар үхэр; хөл хазгар болох.*

ХАЗГАР II хазгай, буруу, хар санаатай.

ХАЗГАРДАХ I хэтэрхий хазгар болох.

ХАЗГАРДАХ II хазгай, хуурмаг санаагаар явах.

ХАЗГАРЛАХ уруу буруу санаа гаргах.

ХАЗГАРЛУУЛАХ хазгарлахын үйлдүүлэх хэв.

ХАЗГАРТАЙ буруу санаатай, хуурмаг.

ХАЗДАГ хазамтгай зантай; *хаздаг гүү.*

ХАЗЛАХ байн байн хазах.

ХАЗЛУУЛАХ хазлахын үйлдүүлэх хэв; *малаа тогтоож бага зэрэг өвс хазлуулъя.*

ХАЗУУЛАХ 1. хазахын үйлдүүлэх хэв; 2. хазахад өртөгдөх, хазагдах.

ХАЗУУР хазах юм; *хазуур сайтай; хазуур муутай.*

ХАЗУУРДАХ хазуураар хазуулах.

ХАЗЧИХ 1. олон удаа буюу байн байн хазах; 2. нэгэнт хазах, хазаж орхих; *тас хазчих.*

ХАЙ I ю у л бол доо, мэдэхгүй гэж тээнэгэлзэн өгүүлэхэд хэрэглэх аялга; *хай даа, мэдэхгүй! хай, горигүй байх аа!* **хай л даа** (харин л даа); **хай хай** (болгоомжлох аялга; *хай хай юу л бол доо!*).

ХАЙ II ай, танил талаа; *хай хайгаа татах; хай хайгаа хамгаалах.*

ХАЙВ I өргөн хавтгай иргүүлтэй тогоо; *хайв тогоо.*

ХАЙВ II бяцхан дорвого тогоо.

ХАЙВ III мэдлэг мэдэц тэгш сайн; *хайв хүн.*

ХАЙВАЛЗАХ хайвганах, дайвалзах.

ХАЙВАЛЗУУЛАХ хайвалзахын үйлдүүлэх хэв.

ХАЙВАЛЗУУР гуйвах, дайвах хялбар.

ХАЙВАХ 1. зүүн баруун тийш дайвах, гуйвах; 2. шувуу ба малын усчлан явах.

ХАЙВГАНАХ 1. хоёр тийш баахан ганхаж явах; *хайвганан жороолох;* 2. дайвганах.

ХАЙВГАНУУЛАХ хайвганахын үйлдүүлэх хэв.

ХАЙВГАСХИЙХ хайвганахын хоромхон үйлдэх байдал.

ХАЙВРИС хэлтрэс далжис; **хайврис гэлдэрс, хайврис далжис** х о р ш..

ХАЙВУУЛАХ хайвахын үйлдүүлэх хэв, дайвуулах.

ХАЙГА а м ь т а н өргөн хавтгай биетэй, эртгэр амтай, нарийн хайрстай нэгэн зүйл загас.

ХАЙГУУЛ 1. ямар нэгэн зорилгоор тусгайлан судлах, сурвалжлах ажил; *хээрийн малтмалын хайгуул; нефтийн хайгуул; хайгуул хийх;* 2. дайсан этгээдийн цэрэг, байр байдлыг сэргийлэн тагнах, сурвалжлан мэдэх зорилго бүхий бүлэг хэсэг цэрэг, жижиг анги; *манай салаа хайгуулд гарав;* ☆ **хайгуул халхавч** х у у ч и р с а н (итгэл гүшиг).

ХАЙГУУЛГАЛАХ хайгуул хийх, хянаж сэргийлэх.

ХАЙГУУЛЧ хайгуул хийж яваа хүн.

ХАЙГУУР 1. хянуур, ажигч; 2. хайнга.

ХАЙГУУРГҮЙ ажиггүй, тоомсоргүй.

ХАЙДАА у р г а м а л далайн усанд ургадаг, хэлбэр хавтгай, өнгө харвор ногоон нэгэн зүйл ногоо, хүнс ба эмнэлэгт хэрэглэдэг, ханин ч гэдэг.

ХАЙДАГ I төлгүй саалгадаг; *хайдаг үнээ; хайдаг ямаа.*

ХАЙДАГ II зуйрган, ховсоргоч; *хайдаг хүн;* ☆ **хайдаг морь** (хөтөлгөөгүй дан морь); **хайдаг мод** (онгоцны ёроолын нийлэлтийн газарт нуруу барьж шууд хадсан мод); **тохмын хайдаг** (тохмын жийрэг хөлсөвч).

ХАЙДАГЛАХ зуйрган зангаар ховсрох.

ХАЙДАГРАХ хайдаг болох, зуйрах, ховсрох.

ХАЙДАГТАХ зусар зуйрган зан гаргах.

ХАЙДАГШИХ хайдаг болох; *хайдагшсан үнээ.*

ХАЙДАГШУУЛАХ хайдагшихын үйлдүүлэх хэв; *үнээ хайдагшуулах.*

ХАЙЛААС у р г а м а л навчит мод, мод нь уян бөгөөд бэх.

ХАЙЛАГДАХ хайлахын үйлдэгдэх хэв.

ХАЙЛАЛТ хайлсан нь; *болд хайлалт; ширэм хайлалт.*

ХАЙЛАН I нэгэн зүйл нарийн бөс барааны нэр, зарим нутагт гөлөнгөр ч гэдэг.

ХАЙЛАН II х у у ч и р с а н буддын шашны гэлэн гэцэл санваартны санваар сахих нэгэн зүйл хурал.

ХАЙЛАХ I 1. тос, цас мөс, төмөрлөг эрдсийн зүйл халууны илчид шингэн болох мөн тэдгээрийг халууны илчээр шингэн болгох; *цас хайлж дулаарав; мөс хайлж устай болов; зуух дотор тавьсан тугалга хайлж хоцорчээ; ширэм хайлж болд хийх;* 2. ш и л ж с э н уйлах; **уйлах хайлах** х о р ш..

ХАЙЛАХ II юмны юманд уусах мөн уусгах; *усанд давс хайлах; цайд чихэр хайлах.*

ХАЙЛГАН: хайлган цаг малын тарга хүч туувардаж хялбархан эцэнгэрэх үе; *намрын хайлган цагт малыг ширүүн тууж болохгүй!*

ХАЙЛГАНА цахлай шувууны өөр нэр.

ХАЙЛГАХ хайлахын үйлдүүлэх хэв, хайлуулах. уусгах, уусгуулах, шингээх.

ХАЙЛГУУР юм хайлгах сав; *цавууны хайлгуур.*

ХАЙЛДАН илгэн өмд.

ХАЙЛМАГ 1. хайлсан юмны царцаагүй, хөлдөөгүй байх үе; *хайлмаг цас;* 2. сүүний өрмийг хайлуулж хийсэн нэгэн зүйл идээ; *хайлмаг тос.*

ХАЙЛМАГЛАХ хайлмаг болгох, хайлмаг байдалтай болох.

ХАЙЛМАГРАХ хайлмаг болох.

ХАЙЛМАГТАХ хайлмаг янзтай болох.

ХАЙЛМАГШИХ хайлмаг шинжтэй болох.

ХАЙЛМАЛ хайлсан юм; *хайлмал шил; төмрийн хайлмал.*

ХАЙЛС у р г а м а л хайлаасны төрлийн нэгэн зүйл мод.

ХАЙЛУУЛАХ 1. хайлахын үйлдүүлэх хэв; 2. хайлагдах.

ХАЙЛУУР хайлгуур; **хайлуур жонш** (жоншийн нэг зүйл).

ХАЙЛЦ хайлах чанар, хайлах үйлийн нэр; *хайлц сайтай; хайлц муутай.*

ХАЙЛЦГҮЙ хялбар хайлахгүй, хайлц муутай.

ХАЙЛШ хайлсан юм; *төмөрлөгийн хайлш.*

ХАЙМСАХ хаймуураар хол харвах; *сум хаймсах.*

ХАЙМУУР төмрөөр хийсэн хол харвах нарийн сум; *хаймуур сум.* •

ХАЙН наадах, барилдах зэрэгт тэнцэх, аль алин нь хожилгүй болох; *бид хоёр шатар тоглоод хайн болов.*

ХАЙНАГ монгол үхэр сарлаг хоёрын хоорондоос төрсөн бэсрэг үхэр; *хайнагийн шар;* **наран хайнаг** (монголын бух эцэгтэй хайнаг); **саран хайнаг** (сарлагийн бух эцэгтэй хайнаг).

ХАЙНГА нягт нямбай биш, алгасангүй, цалгар, назгай ,салан; *хайнга хандаж осолдох; хайнга үйлдэх.*

ХАЙНГАДАХ хэтэрхий хайнга болох.

ХАЙНГАРАХ хайнга болох.

ХАЙНГАТАХ хайнга байдал гаргах.

ХАЙНГАШИХ хайнга шинжтэй болох.

ХАЙНЦААХ хайнцуулах.

ХАЙНЦАХ 1. барилдаж байгаа хоёр бөхийн нэг зэрэг унах; *хайнцсан бөхийг дахин барилдуулав;* 2. шатар мэтийн наадам тэмцээнд хожилгүй болох, харилцан тэнцэх; *бид хоёр хайнцав.*

ХАЙНЦУУЛАХ хайнцахын үйлдүүлэх хэв.

ХАЙР I 1. дотночлох сэтгэл, дотнолох сэтгэл; *хайраа дотроо, халаа гаднаа* з ү й р; **хайр хүрэх** (дотнолох сэтгэл төрөх); **хайр булаах** (дур маш татах); **хайр ихтэй** (маш хайртай, маш янаг); **хайрын сэтгэл** (янагийн сэтгэл, дотнын сэтгэл); **эхийн хайр** (эхийн энэрэл, өрөвч сэтгэл); **халуун хайр** (маш дотно сэтгэл); **хайр дурлал** (янаг амрагийн дотнолох сэтгэл); **хайр найргүй, хайр гамгүй** (гамгүй, хайрлах сэтгэлгүй): 2. **өршөөл, хишиг; хайр хишиг, өршөөл хайр, хайр хүндэтгэл** х о р ш.; *нам засгийн минь хайр хишиг.*

ХАЙР II жижиг чулуу; *хайр дэвсэх; хайртай газар.*

ХАЙРАГДАХ 1. хайрахын үйлдэгдэх хэв; 2. халуун хүйтэнд бие махбод бага зэрэг түлэх хэлдөх; *халуун зууханд хайрагдах; хүйтэнд хайрагдах.*

ХАЙРАН харамсахад гаргах аялга; *хайран сайхан хувцсы минь урж орхижээ! хайран санагдаж байна! хайран юм!*

ХАЙРАРХАГ хайр ихтэй, хайрархуу; *хайрархаг газар.*

ХАЙРАРХУУ 1. хайрархаг; 2. хайр мэт.

ХАЙРАХ I 1. халуун төмөр, чулуу мэтийг юманд хүргэж түлэх; *халуун төмрөөр хайрах;* 2. идээний зүйлийг гал дээрх халуун тогоо, саван дээр жигнэж болгох; *хуушуур хайрах; бин хайрах;* 3. хүйтэн юмыг хүргэн жигнэх; *хаалганы бариул гар хайрч байна; хүйтэн дээлээр хайрах.*

ХАЙРАХ II морь малын хойт хөлөөр урагш хавиран өшиглөх; *олмоо татахад хайрдаг морь.*

ХАЙРГА 1. ширүүн билүү; 2. маш үүрмэг чулуу.

ХАЙРГАДАХ хэтэрхий хайрга болох.

ХАЙРГАЖИХ хайргатай болох.

ХАЙРГАЛАХ хайргатай болгох.

ХАЙРГАЦАЙ а м ь т а н богшоргоноос томхон, ар улаавтархан, өвчүү цагаавтархан, ихэд жиргэдэг нэг зүйл бялзуухай.

ХАЙРГАШИХ хайрга шинжтэй болох.

ХАЙРГҮЙ хайртай биш, гамгүй; *хайргүй болох; хайргүй эдлэх.*

ХАЙРЛАГДАХ хайрлахын үйлдэгдэх хэв; *олон түмэндээ хайрлагдах.*

ХАЙРЛАЛ хайрлах үйлийн нэр.

ХАЙРЛАЛТ хайрласан нь; *хайрлалт хамгаалалт* х о р ш..

ХАЙРЛАЛТАЙ хайрлаж байвал зохих, хайрламаар.

ХАЙРЛАХ 1. элбэрэн дотночлох; *хүүхдийг хайрлан өсгөх; хайрлах сэтгэл цээж дүүрэн; хайрласан нохой хацар долоох* з ү й р; 2. гамнах, арвилах; **хайрлах гамнах** х о р ш.; *сайхан дээлээ хайрлаад өмсдөггүй байжээ; улсын хөрөнгийг нүдний цөцгий мэт хайрлах;* 3. х у у ч и р с а н өгөхийн хүндэтгэл; *над хишиг хайрлаж билээ;* 4. гуйх, хүсэх утгаар; *та хэлж хайрал! дуугарч хайрал! айлдаж хайрлахсан болов уу.*

ХАЙРЛУУЛАХ 1. хайрлахын үйлдүүлэх хэв; 2. хайрлагдах.

ХАЙРЛУУШТАЙ хайрлаж байгууштай, хайрлавал зохистой.

ХАЙРМАЛ хайрч болгосон идээ; *хайрмал боорцог.*

ХАЙРС зарим амьтан, ургамлын бие дээгүүр бүтээн орших бие биеийн ирмэгийг дэрлэж тогтсон эвэрлэг ялтас; *загасны хайрс; могойн хайрс.*

ХАЙРСЛАХ 1. хайрсыг арилгах, хусах; *загас хайрслах;* 2. юманд хайрс нааж тогтоох.

ХАЙРСЛУУЛАХ хайрслахын үйлдүүлэх хэв.

ХАЙРТ хайр сэтгэл бий; *хайрт нөхөр; хайрт хүү; хайрт минь !хайрт намдаа.*

ХАЙРТАЙ хайр сэтгэл бүхий, дотночлох сэтгэлтэй; *хайртай хүү; эх орондоо хайртай; хайртай морио өгч явуулав; хайртай боловч хайчаар бүү наадуул, эрх боловч ээрүүлээр бүү наадуул* с э ц э н.

ХАЙРУУЛ халааж юм хайрах хэрэгсэл; *хайруул төмөр; хайруул таваг.*

ХАЙРУУЛАХ хайрахын үйлдүүлэх хэв.

ХАЙРХАГ хайр чулуу ихтэй.

ХАЙРХАН I х у у ч и р с а н хүндэтгэх бишрэх, нэрийг цээрлэхэд хэлэх үг; *хайрхан уул;* **урт хайрхан** ц э э р л э с э н (могойн өөр нэр).

ХАЙРХАН II хайран.

ХАЙРЦАГ 1. юм агуулах, **голдуу дөрвөлжин** хэлбэргэй жижгэвтэр сав; *шүдэнзний хайрцаг; авдар хайрцаг;* 2. ш и л ж с э н төрх, хэв, хэлбэр; *хайрцаг сайтай морь;* 3. аман доторхи зай; *амны хайрцаг.*

ХАЙРЦАГЛАХ хайрцагт агуулах; **бөх хайрцаглах** (дөрвөлжин өрж зогсох буюу барилцаж дөрвөлжлөх).

ХАЙРЦАГЛУУЛАХ хайрцаглахын үйлдүүлэх хэв.

ХАЙС I голдуу гоёмсоглон янзалж хийсэн намхан хүрээ хашаа; *цэцэрлэгийн хайс; төмөр хайс.*

ХАЙС II жижиг дорвого тогоо.

ХАЙСАН 1. сэхээ гаргаж байгуулсан хэрэм; 2. хайс.

ХАЙСЛАХ юманд хайс хийх

ХАЙСЛУУЛАХ хайслахын үйлдүүлэх хэв.

ХАЙТАН: хайтан цэцэг у р г а м а л өндөр нь хос алд хир, ягаан улаан цэцэгтэй, хавар цэцэглэдэг нэг зүйл цэцэг.

ХАЙХ эрэх, сураглах; **эрэх хайх** х о р ш.; *олз хайх; ажил хайх; алдуулыг хайх.*

ХАЙХРАГДАХ хайхрахын үйлдэгдэх хэв.

ХАЙХРАМЖ 1. болгоомж, анхаарал; *хайхрамж сайтай байсан бол ийм хэрэг гарахгүй байсан юм;* 2. анзаарга.

ХАЙХРАМЖГҮЙ 1. болгоомжгүй, анхааралгүй; *хайхрамжгүй сул задгай орхисноос болсон байна;* 2. анзааргагүй; *хайхрамжгүй хүн.*

ХАЙХРАМЖГҮЙДЭХ хэтэрхий хайхрамжгүй байх.

ХАЙХРАМЖЛАХ 1. анхаарал, болгоомж тавьж байх; 2. анзаараггатай байх.

ХАЙХРАМЖТАЙ 1. болгоомжтой, анхааралтай; 2. анзаараггатай.

ХАЙХРАХ анзаарах, анхаарах, хэрэгсэх; *хайхарч үзэх; тэнд зогсч байхад нь ер хайхарсангүй: хайхрах цаг болжээ.*

ХАЙХРУУЛАХ 1. хайхрахын үйлдүүлэх хэв; 2. хайхрагдах.

ХАЙЧ (ИН) I 1. хооронд нь нугаслан холбосон гуя гэдэг хоёр нарийн төмөрт ир гаргаж, цагариг мэт бариул хийсэн хайчлах, огтлох зэвсэг; *үйлний хайч; төмрийн хайч;* **хайчны бариул** (хайчны барих иш этгээд); **хайчны ааг** (хайчны ирийн уг этгээд); 2. хооронд нугаслан холбосон юм хавчих хоёр гуя төмөр; *галын хайч;* **хайч солбих** (хайчны гуя хэтрэн зөрөх); **хайч боорцог** улаан хоног амууг жигнэж, хольц холин, хайчны бариул мэт мушгин хийж тосонд буцалгасан нэг зүйл боов); **хайч хорхой** а м ь т а н (олон хөлтэй, хар өнгөтэй, хатуу хальстай, эрүүндээ хорт булчирхайтай шавьж).

ХАЙЧ II хилийн харуулын хүмүүсийн хариуцсан газраа эргэж үзээд харилцан уулзах тэмдэгт газар; *хилийн хайч; хайч солих.*

ХАЙЧИН шонхор шувууны өөр нэр; **хайч өвс** у р г а м а л (нэгэн үндэснээс салаалж солбицон ургадаг, хавтгай навчтай цэцэггүй ургамал).

ХАЙЧЛАХ 1. хайчаар огтлох, хяргах; *эсгий хайчлах;* 2. ш и л ж с э н бие биений мөрийг ташуу хөндлөн огтлон самнаж явах; *эрлийн хүмүүс хайчилж эрээд олсонгүй; хилийн маная хайчлан явав.*

ХАЙЧЛУУЛАХ хайчлахын үйлдүүлэх хэв.

ХАЙЧЛУУР гарын аль нэгэн хурууны үзүүр өндөг битүү хавдаж өвчлөх өвчин

ХАЙЧЛУУРТАХ хайчлуур өвчин тохиолдож өвдөх.

ХАЙЯ адуу малыг зандаж хашгирах аялга; *хайя, хайя!*

ХАЛ I 1. бэрхшээл, хөнөөл, зүдгүүр; **хал хөнөөл, хал дол, хал зүдгүүр, хал хашрал** х о р ш.; *хал үзэж хашир таних* з ү й р; *хал үзсэн хүн;* **хал авах** (а. зовлон зүдгүүрээс хаширч бэрхшээх болох; б. бусдад хорсон гомрохож өшөө өвөрлөх); **хал авахгүй** (зовооход авд гомдохгүй); **хал үзэх** (зовох зүдэхийг олонт үзэж өнгөрүүлэх); **хал балгүй** (гэм хоргүй, түвэг чирэгдэлгүй; *хэн хэндээ хал балгүй нь дээр);* 2. гэм, зэм, хөнөөл, харш; *хатуу ажил хувцсанд халтай; урт хушуу толгойд халтай; чулуутай газар гуталд халтай.*

ХАЛ II нэгэн зүйл хөгжим, хэлбэр хонхтой адил бөгөөд том, ширэм хүрлээр хийнэ, гол төлөв урианд хэрэглэнэ, бас жин ч гэдэг.

ХАЛАА юмны солио, ээлж, сэлээ; **манаа халаа** х о р ш.; *халааны нь хүн ирэв; халаа авах; халаа авалцах; халаа өгөх;* **хувцасны халаа** (хувцасны ор, солио).

ХАЛААГҮЙ 1. ээлж халаа байхгүй, сэлгээ солио байхгүй; 2. халагдаагүй.

ХАЛААД хувцасны гадуур давхацлан өмсөх хувцас.

ХАЛААЛГАХ халаахын үйлдүүлэх хэв.

ХАЛААХ халахын үйлдүүлэх хэв, халахад хүргүүлэх; *халаасан хоол.*

ХАЛААХАЙ халгай.

ХАЛАГ гаслах, харамсах аялга; **халаг хухуй** х о р ш.; *халаг, бяцхан хожимдов! ээ, халаг, тэрүү дээ!*

ХАЛАГДАХ халах II-ын үйлдэгдэх хэв; **халагдах солигдох** х о р ш.; *ажлаас халагдах.*

ХАЛАГЛАХ 1. халаг гэж харамсан гаслах; 2. ямар нэгэн үйлд дурлан тэсч ядах; *анд явах юм сан гэж халаглаж байсаар өнгөрөв.*

ХАЛАГТАЙ халагцай, халахцай.

ХАЛАГЦАЙ халхай, халахцай.

ХАЛАЙХ 1. хүндэтгэвэл зохих хүний энд тэнд зорчин явах; 2. харах, ажих, ажиглах; **харах халайх** х о р ш.; 3. тус болох; *манай аав өнөөдөр над юм халайх болов уу.*

ХАЛАЛЦАХ халах II-ын үйлдэлцэх хэв, халаа авалцах, солилцох.

ХАЛАЛЦУУЛАХ халалцахын үйлдүүлэх хэв.

ХАЛАМЖ асрамж, тэтгэмж, хайрлах санаагаар үзүүлэх тус; *халамжтай сайн нөхөр; халамжит хань нөхөд.*

ХАЛАМЖГҮЙ хайрлах, асрах санаа байхгүй, асрамжгүй.

ХАЛАМЖЛАХ халамж үзүүлэн хүртээх; *эхнэрий нь биеийг өвчтэй байхад сайтар халамжилж байв.*

ХАЛАМЖЛУУЛАХ халамжлахын үйлдүүлэх хэв.

ХАЛАМЖТАЙ хайрлах, асрах сэтгэл бүхий.

ХАЛАМСАХ халамцах.

ХАЛАМСУУЛАХ халамсахын үйлдүүлэх хэв.

ХАЛАМЦАХ архи, сархдад нилээд согтох, халамсах.

ХАЛАМЦУУ халамцсан, архи сархдад халсан, нилээд согтуу.

ХАЛАМЦУУЛАХ халамцахын үйлдүүлэх хэв.

ХАЛАМЦУУХАН нилээд халамцуу.

ХАЛАНГИ 1. ялихгүй согтож ярих дур нь хөдлөх; *ам халанги;* 2. ярь ярьсаар яриа хэтрэхий нь; *ам халанги дээрээ байна.*

ХАЛАНХАЙ түлэгдсэн зэргээс гарсан татанхай ором сорви; **халанхай татанхай** х о р ш.; *халанхай хацартай.*

ХАЛАХ I 1. халуун болох; *ус халав; наранд халах;* 2. хэтэрхий халуунд нэрвэгдэх, түлэгдэх; *ууранд шударч гар халав; сүүнд халаад, тараг үлээх* з ү й р; 3. ш и л ж с э н баахан согтох; **ам халах** (үг олшрох, яриа ихдэх); 4. ш и л ж с э н нилээд хөдөлж бие дасч таатай болон урамших, зоригших; *халж ирэхдээ явдал нь нэмэгдэх морь;* 5. ш и л ж с э н ичих, зовох; *нүүр халах.*

ХАЛАХ II 1. солих, сэлэх, ээлжлэх; *барилаа халах; халж барих;* 2. тушаал, ажлаас огцруулах, ажиллахгүй болгох; *албан тушаалаас халах.*

ХАЛАХ III 1. ойртох, халдаж очих; *халж хавьдахын аргагүй;* **халж очих** (ойртон очих); 2. **өдөөх;** *халж өдөөх; халж шоглох;* 3. халшрах, бэрхшээх; **хөл халах** (морь малын хөл чөдөр тушаандаа холгогдох); **дотор халах** (өрөн дээр төөнөрөх); **эдлэгээнд халах** (эдлэгээнд малын бие булрах).

ХАЛАХГҮЙ 1. халдаж ойртохгүй; 2. сольж өөрчлөхгүй

ХАЛАХЦАЙ халуун юманд бие гэнт хүрч халахад гаргах аялга, халагцай, халхай; *халахцай, ямар халуун юм бэ!*

ХАЛБАГА I шингэн буюу үйрмэг зүйлийг утгах хэрэгсэл; *цайны халбага; хоолны халбага; халбага шанага.*

ХАЛБАГА II: **халбага халбага хийх** халбагар юмны үргэлжлэн хөдлөх.

ХАЛБАГАДАХ халбагаар утгах; *шөл халбагадах; тараг халбагадах.*

ХАЛБАГАДУУЛАХ халбагадахын үйлдүүлэх хэв.

ХАЛБАГАЛАХ 1. халбагадах; 2. халбагаар утгаж хэмжих.

ХАЛБАГАНАХ халбагар юмны халбага халбага хөдлөх.

ХАЛБАГАНУУЛАХ халбаганахын үйлдүүлэх хэв.

ХАЛБАГАНТ I а м ь т а н дэглийтэй адил, хушууны үзүүр нь өргөн нэгэн зүйл шувуу.

ХАЛБАГАНТ II хөлийн шилбэний арын зузаан булчин шөрмөс.

ХАЛБАГАР дүр байдал хэвийн жишээнээс өргөн, халхгар, хэлхгэр; *халбагар хүрэм; халбагар дах.*

ХАЛБАЙЛГАХ халбайхын үйлдүүлэх хэв, халбагар болгох.

ХАЛБАЙХ халбагар болох.

ХАЛБАЛЗАХ халбагар юмны байн байн хөдлөх.

ХАЛБАЛЗУУЛАХ халбалзахын үйлдүүлэх хэв.

ХАЛБИГЛР дүр байдал хэвийн жишээнээс дэлбэгэр өргөн; *халбигар навч; халбигар таваг.*

ХАЛБИЙЛГАХ халбийхын үйлдүүлэх хэв, халбигар болгох.

ХАЛБИЙХ халбигар болох.

ХАЛБИНЬ а м ь т а н янз шаахайн ултай адил, нэгэн этгээдэд хайрстай, нөгөө этгээд нь хайрсгүй, хоёул нийлсэн хойно явж чаддаг нэгэн зүйл загас.

ХАЛГАА 1. халтираа, халтирах газар; **халгаа халтираа** х о р ш.; *даваа халгаа ихтэй байна;* 2. ш и л ж с э н хэцүү байдал, түвэг ярвиг их; *халгаатай хэрэг; халгаатай зан.*

ХАЛГААТАЙ халгаа бүхий; *ханилахад халгаатай хүн; унахад халгаатай морь; биенд халгаатай ажил.*

ХАЛГААХ халгахын үйлдүүлэх хэв, ойртуулах.

ХАЛГААХГҮЙ биеэсээ зайцуулах, биедээ хавьдаж ойртуулахгүй; *хүрэгч үнээ тугалаа огт халгаахгүй байв.*

ХАЛГАЙ у р г а м а л иш ба навчиндаа түлэх өргөс бүхий өвсөрхөг ургамал; *халгай хатгах; халгайд түлэгдэх.*

ХАЛГАЙДАХ халгайгаар ороолгох, гуядах.

ХАЛГАЙДУУЛАХ 1. халгайдахын үйлдүүлэх хэв; 2. халгайдагдах.

ХАЛГАРАХ байн байн гулгах болох.

ХАЛГАХ I халтирах, гулгах.

ХАЛГАХ II халж ирсэн юмыг хавьдуулах, ойртуулах, хүлээн авах; *дэргэдээ халгаж агуулах.*

ХАЛГАХ III айх бэрхшээх; *хүйтнээс халгаад гарч чадахгүй байна.*

ХАЛГИА халгих үйлийн нэр, *халгиа ихтэй; халгиа муутай.*

ХАЛГАХГҮЙ хавьтуулахгүй, ойртуулахгүй; *биендээ огт халгахгүй байв.*

ХАЛГИДАС халгиж гарсан юм.

ХАЛГИЛАХ байн байн халгих.

ХАЛГИУЛАХ халгихын үйлдүүлэх хэв.

ХАЛГИХ 1. юмыг саванд хийхэд амсрыг даван гарах буюу цалгих; **халгих цалгих** х о р ш.; 2. юм хумыг хэмжээлэхэд илүүдэж хальсах; *халгиж илүү гарах* 3. идсэн уусан юм зохихгүй бяцхан бөөлжих; **гулгих халгих** х о р ш..

ХАЛГИЦ халгих үйлийн явц; *халгиц сайтай; халгиц багатай.*

ХАЛД аврага загасны дэлүү.

ХАЛДААЛГАХ халдаахын үйлдүүлэх хэв, халдварлуулах.

ХАЛДААХ халдахад хүргүүлэх; *өвчин халдаах; халдааж авах.*

ХАЛДАГДАХ халдахын үйлдэгдэх хэв.

ХАЛДАМГАЙ 1. халдаж наалдах чанартай, халдамтгай; *халдамгай чанар;* 2. халдварлахдаа халбар; *халдамгай өвчин;* 3. бусдад халдах, бусадтай шөргөөлдөх зантай; *халдамгай зан.*

ХАЛДАМТГАЙ халдамгай.

ХАЛДАМХАЙ 1. халдахдаа хялбар; *халдамхай өвчин;* 2. бусдад халдах зантай; *халдамхай хүн.*

ХАЛДАХ 1. юманд хүрч наалдах; *ус үл халдах цув; тос халдахгүй эд;* 2. шилжсэн ойртон очих, дэргэд нь очих, тулж очих; *халдаж чадахгүй тойрон явах; халдвал хар халзандаа зүйр;* 3. халдварлах, халдварлан өвдөх; *халдах өвчин;* 4. ял хэрэгт холбогдон орох; *хэрэг халдах; ял халдах;* 5. юм явдал дамжин нөлөөлөх; *муутай нөхөрлөвөл муу нь халдах, сайн нь халдахын урьд муу нь халддаг хуучлах;* 6. түрэмгийлэх, хүчлэх, эзэрхэх; *эрхэнд халдах; аминд халдах; хөрөнгөнд нь халдах; халдан довтлох.*

ХАЛДАЦ халдах үйлийн явц, халдах чанар, халдаж хоцорсон нь; *халдац сайтай; халдац муутай.*

ХАЛДАЦГҮЙ халдах наалдах нь муу, үлдэц муутай.

ХАЛДАЦТАЙ халдах наалдах нь сайн, үлдэц сайтай.

ХАЛДАШГҮЙ халдаж болшгүй, ойртох аргагүй; *халдашгүй эрх.*

ХАЛДВАР 1. бусдад дамжин нөлөөлөх нөлөө; *зан заншлын халдвар; суртал журмын халдвар;* 2. өвчний бусдад дамжиж шилжин хүрэх; *өвчний халдвар; халдварыг арилгах.*

ХАЛДВАРГҮЙ халдаж нөлөөлөх юмгүй.

ХАЛДВАРГҮЙТГЭХ халдварлах шалтгааныг үгүй болгох.

ХАЛДВАРЛАХ 1. үйл явдлын дамжин нөлөөлөх; *суртал нь халдварлах; зан авир нь халдварлах;* 2. өвчний дамжин хүрэх; *өвчин халдварлах.*

ХАЛДВАРЛУУЛАХ халдварлахын үйлдүүлэх хэв, халдаах.

ХАЛДВАРТ 1. нөлөөтэй; 2. халдвар бүхий; *халдварт өвчин.*

ХАЛДВАРТАЙ халдвар бүхий, халдварлахдаа хялбар.

ХАЛДЛАГА халдах өдөх үйлийн нэр; *дайсны халдлага.*

ХАЛДУУЛАХ 1. халдахын үйлдүүлэх хэв, халдаах; 2. халдагдах.

ХАЛЗ I бэх ба бэхний ус агуулах бяцхан сав; *бэхний халз.*

ХАЛЗ II 1. ямар нэгэн юмны ам амсар заагийн хоёр талаар чимэглэл болгож өөр өнгийн юмаар хийсэн туус зурвас юм; *гутлын халз; хөөрөгний савны халз;* 2. хуучирсан монгол гэрийн бүрээсний дээгүүр дөрвөн тийш дарж татах зурвас бүс, хөлтрөг ч гэдэг; *гэрийн халз; улаан халзтай гэр.*

ХАЛЗ III эгц өөдөөс, яг өөдөөс; *халз мөргөлдөх;* **халз дайрах** (яг чиглэн дайрах); **халз тулгарах** (явхийтэл тулгарах); **халз үзэх** (а. тоглоом, наадамд хоёулхнаа тулгар тоглох; б. хоёулхнаа тэмцэлдэх, тулах).

ХАЛЗ IV 1. хамар, гүвгэр; *халзаар давах; халз дээрээс харах;* 2. хад асгатай газрын доторхи хэсэгхэн цулгуй газар; *уулын халз;* 3. ой модтой газрын доторхи цулгуй газар; *ойн халз.*

ХАЛЗАВТАР халзаншиг, халзан мэт.

ХАЛЗАН 1. адгуус амьтны магнайн дагуу дахь зурвас цагаан үс; *зээрд халзан азрага; бор халзан хонь;* 2. хүний толгойн үс магнайгаас эхлэн дээш байхгүй буюу сийргий нь; *халзан толгой; халзан болох;* 3. ойт уулан дахь модгүй зурвас газар; *халзан хөтлөөр давах;* **халзан ангир** амьтан (нэг зүйл уран хажин шувуу).

ХАЛЗЛАХ 1. халзтай болгох; *халзалж оёх;* 2. халзан болгох, халзруулах.

ХАЛЗЛУУЛАХ халзлахын үйлдүүлэх хэв.

ХАЛЗРАХ халзан болох.

ХАЛЗРУУЛАХ халзрахын үйлдүүлэх хэв.

ХАЛИА мөсний дээгүүр урссан ус; *халиа гарах; халиа урсах.*

ХАЛИАДАХ махыг нимгэн болгож огтлох.

ХАЛИАР ургамал уулархаг газар ургах нэгэн зүйл сонгино, навч агшрагын навчтай адил болоод бяцхан, иш саримсгийн иштэй адил болоод өндөр, үнэр сайхан, дарах буюу түүхийгээр иднэ; *халиартай хуушуур; халиар түүх.*

ХАЛИАТАХ халиа гоггох.

ХАЛИАТУУЛАХ халиатахын үйлдүүлэх хэв.

ХАЛИАХ I бусдаас зэвүүрхэн эмээсхийх.

ХАЛИАХ II харах, үзэх, анхааран харах.

ХАЛИАХ III халихын үйлдүүлэх хэв.

ХАЛИВ I хавхаг, таг, таглаа; *тогооны халив; авдрын халив.*

ХАЛИВ II эргүүлэх, эрэг шургийг эрэх, чангалах, сугалахад хэрэглэх багаж.

ХАЛИВДАХ халиваар эрэгдэх.

ХАЛИВДУУЛАХ халивдахын үйлдүүлэх хэв.

ХАЛИВЛАХ хавхаглах, таглах; *авдар халивлах хэрэгтэй.*

ХАЛИЛ цавчим өндөр уул, түн бэрх газар, маш өндөр эрэгцэг; **нисэл халил** х о р ш..

ХАЛИМ I а м ь т а н далайн хөхөн тэжээлт маш том амьтан, биеийн хэлбэр загас мэт, буу загас ч гэдэг.

ХАЛИМ II арьсны хамт өвчигдсөн өөх, чанасан махны өөхний дээгүүр байх өнгөн хальс.

ХАЛИМ III халиа.

ХАЛИМАГ I Зөвлөлт Улсын нутагт бий монгол аймаг, автономит Халимаг мужийн үндсэн хүн ам.

ХАЛИМАГ II хүний толгойн үсийг засч ургуулах нэгэн маяг; *халимаг тавих; битүү халимаг; задгай халимаг.*

ХАЛИМАЛ I усны уул урсах сав газраас давж урссаны нь; *халимал ус.*

ХАЛИМАЛ II түүхий нимгэн нимгэн хэсэглэж эгшээсэн мах; *халимал мах.*

ХАЛИМДАХ амьтны арьс махны завсраар юм хавж орох.

ХАЛИМЛАХ халимыг өвчиж хуулах; *чанасан ууцыг халимлаж байв.*

ХАЛИМЛУУЛАХ халимлахын үйлдүүлэх хэв.

ХАЛИМТАХ I арьсыг өвчихөд түүнд халим наалдан үлдэх.

ХАЛИМТАХ II үс цасны дээгүүр өрөмтөн хөлдөх.

ХАЛИМТУУЛАХ халимтахын үйлдүүлэх хэв.

ХАЛИРАХ I сүр буюу халаас бэрхшээх, мятрах, зүрхших.

ХАЛИРАХ II 1. мятрах, няцах, халшрах; 2. морь мал юмнаас үргэсхийх; 3. ирт үзүүрт юмны ир үзүүр нь шантрах, мохох.

ХАЛИРУУЛАХ халирахын үйлдүүлэх хэв.

ХАЛИРХАЙ аймхай, мятрамхай.

ХАЛИУ (Н) а м ь т а н 1. суусрын аймгийн, усанд сэлдэг араатан амьтан, мөн түүний арьс, сайн чанарын үстэй; 2. халиуны үсээр хийсэн юм; *халиун зах; халиун малгай.*

ХАЛИУГЧ халиун зүсмийн охин мал; *халиугч гүү; халиугч үнээ.*

ХАЛИУЛАХ халихын үйлдүүлэх хэв, халихад хүргүүлэх.

ХАЛИУН адуу үхрийн зүсэм, бүдэх цайвар үс дийлэнх хольцолдсон өнгө, дэл сүүл хар байх нь олон бөгөөд бас нурууны дагуу хар голтой байх нь бий; *цагаан халиун морь; хар халиун үрээ.*

ХАЛИУРАХ шаравтар буюу цайвар өнгөтэй юмны нэг тийш жигдхэн ханаран налах, найгах; *алтан шаргал тариалан минь, түүний дэнжээр халиуранхан байна* (дуу); *халиурсан үстэй үнэг.*

ХАЛИУРУУЛАХ халиурахын үйлдүүлэх хэв.

ХАЛИХ I бялхах, шингэн юмны савнаас давж асгарах; *гол үерлэн эрэгнээсээ хальж байв; хальтал дүүргэх.*

ХАЛИХ II агаарт өндөр хөөрч эргэлдэн нисэх; *халин нисэх.*

ХАЛИХ III үхэхийн хүндэтгэл; *сүүдэр халих.*

ХАЛИХ IV өндрөөс унах, халилаас унах, нисч унах; *мориноос халих; модноос халих.*

ХАЛМАХ хамах, шингэн юмны дээгүүр тогтсон зүйлийг хамж авах, зарим нутагт хармах ч гэдэг.

ХАЛМУУЛАХ халмахын үйлдүүлэх хэв.

ХАЛСАР а м ь т а н элээтэй адил болоод алаг эрээн өрөвлөгтэй нэгэн зүйл шувуу.

ХАЛСАХ залхаж хашраад халшрах, мятрах, зайлсхийх болох.

ХАЛТ: **халт мөлт** дутуу зэрэмдэг, там тум, хааш яаш, хагас бүтэн; *халт мөлт гүйцээх; халт мөлт ярих.*

· qaltu möltü superficiellement, tant bien que mal [290a MOSTAERT]

ХАЛТАГЧ гүүний халтар зүсэм; *халтагч гүү.*

ХАЛТАЛЖ у р г а м а л нэгэн зүйл хатаалзай.

ХАЛТАН халтар, хиртэй, халтардсан нь; **халтан хултан** (халтар хултар).

ХАЛТАНТАХ халтан болох, халтар болох, хир болох.

ХАЛТАНТУУЛАХ 1. халтантахын үйлдүүлэх хэв; 2. ш и л ж с э н бичгийг баллах, дахиж бичих.

ХАЛТАР 1. амьтны зүсэм, хээр, хар хээр адууны ам, хамар, суга, цавьд цайвар, шарангуй өнгө хольцолдсон нь; *халтар морь;* 2. тэмээний хар зүсэмд шаравтар өнгө хольцолдсон нь; 3. нохойны биеийн зүсэм хар бөгөөд нүд ам, хөлийн орчин үс шар, цайвар газартай нь; *халтар нохой; цагаан халтар; шар халтар;* **дөрвөн нүдтэй улаан халтар нохой** (хоёр нүдний дээр тус бүр нэжгээд бяцхан дүгрэг толботой нохой); 4. үнэгний шар буюу улаан үсэнд хар үс хольцолдсон нь; *халтар үнэг;* 5. ш и л ж с э н цэвэр биш, хир буртагтай, алаг тарлан болсон нь; *халтар болох; дээлээ халтар болгох; халтар нүүртэй;* **халтар хултар** (алаг цоог, энд тэнд, хагас дутуу; *халтар хултар унших; нүүрээ халтар хултар угаах);* **халтар ухна** (халтар нүүр царайтай); **халтар мод** (хөлтсөн нь хальчиж аваад хатаасан мод); **халтар нугас а м ь т а н** (өнгө халтар нэгэн зүйл нугас).

ХАЛТАРДАХ хэтэрхий халтар болох.

ХАЛТАРЛАХ 1. халтар болгох; 2. ш и л ж с э н үсэг бичиг мэтийг там тум мэдэх, муу мэдэх; *бичиг жаахан халтарлах төдий.*

ХАЛТАРЛУУЛАХ халтарлахын үйлдүүлэх хэв.

ХАЛТАРТАХ халтар болох; *нүүр халтартах; уулын цас халтартах.*

ХАЛТАРТУУЛАХ халтардахын үйлдүүлэх хэв.

ХАЛТАС хагас хувь, дундуур хувь.

ХАЛТГАНАХ 1. загасны шарвалзан хөдлөх; 2. ш и л ж с э н хүний элсэглэх, дотнолох, еелдэг ааш гаргах; **халтганан шилтэгнэн** (тэсгэлгүй элэгсэг зан байдал гарган).

ХАЛТИ мөлт, мөлтөс, мөчид; *халти гишгэх; халти цохих; халти мөлт уулзав; халти сонсох; халти харах.*

ХАЛТИРАА мөстөсөн, шавартсан гулгах газар; *халтираа ихтэй зам.*

ХАЛТИРАХ гулгах, гулгаж суурь алдах, халгах; *мөсөн дээр халтирч унах; хазгай газар халтирах; хутга халтирах; хэл халтирах.*

ХАЛТИЧИХ байн байн халтирах.

ХАЛТЧИХ 1. модны дурс холтос мэтийг энд тэндээс нь халтардуулан хуулах; 2. ш и л ж с э н бичгийг халт мөлт гаргаж унших.

ХАЛУУ I: халуу мэргэн а м ь т а н шаравтархан өнгөтэй, жигүүр нь урт, сүүл нь охор, хүзүү нь бүдүүн, загас барьж иддэг нэгэн зүйл шувуу: **халуу цэцэг у р г а м а л** (шулуун иштэй, том навчтай, хэлбэр цээнийн цэцэгтэй адил бөгөөд арай жижиг нэг зүйл ургамал).

ХАЛУУ II халуун; **халуу буцлах** (маш халуун болох); **халуу оргих** (маш халах, халуун болох).

ХАЛУУВТАР баахан халуун, халууншиг.

ХАЛУУДАХ хэтэрхий халуун болох.

ХАЛУУЛАХ I халаах.

ХАЛУУЛАХ II халах II-ын үйлдүүлэх хэв; *ажлаас нь халуулах.*

ХАЛУУН 1. бодисын хөдөлгөөний тусгай нэгэн хэлбэр бөгөөд бодисын өчүүхэн хувь молекул, атомын хөдлөхөд бий болох илч; **халуун хүйтэн х о р ш.**; *зуны халуун; гадна халуун байна;* **халуун намар** (намар эрт, зуны эцэс); **халуун ус** (а. халаасан ус; б. бие угаах халуун хүйтэн ус бүхий нийтийн үйлчилгээний газар); **халуун өвчин, халуун хижиг** (биеийн халуун үлэмж болох халдварт өвчин); **халууны эм** (халуун дарах эм); **бага халуун** (Дорно зүгийн зурхайн ёсны жилийн хорин дөрвөн улирлын нэг, зуны нар буцах үес); **их халуун** (Дорно зүгийн зурхайн ёсны жилийн хорин дөрвөн улирлын нэгийн нэр, зуны нар буцсанаас хойших үе); **халуун эгэх** (сарны зурхайн ёсны хорин дөрвөн улирлын нэгний нэр, нарны зурхайн ёсны зургадугаар сарын хорьдын үе, нар буцах ч гэнэ); **халуун ханз** (гал түлэх зуухан ханз); **халуун сав** (хийсэн юмны халууныг удаан хугацаагаар барьж чадах сав); **аагим халуун** (зуны маш халуун); **халууны хэмнүүр, халууны шил** (халууны хэмжээг үзэх хэрэгсэл); **халуун эм**

(эмийн зүйлийн доторхи амт чанар халууны нь); **халуун тогоо** (а. дотор талын гол хөндийд нүүрс хийж халаан, нарийн хоол чанах төмөрлөг хэрэгсэл; б. мөн ус буцалгах тийм хэрэгсэл); **халуун оргих** (а. нар ба гал зэргийн ээлт онц халуун болох; б. хүний бие, өвчнөөр халуун болон эчих зэргээр халуун нь хэтийдэж зовуурьтай болох); **халуун аршаан** (газраас ундран гарах халуун ус); **халуун булаг** (халуун аршаан); **халуун зэвсэг** (хутга шөвөг биш, буу сумны зүйл): 2. амтны хурц бөгөөд гашуувтар, хэл ам дарвигнасан, халуу оргих мэт болох нь; **халуун амт** (поваарь, чинжүү, хуажуу, гаа зэрэг юмны халуу оргих мэт аагт амт); **халуун өвс** у р г а м а л (энхэл тунхал газар хэсэг хэсгээр ургадаг, өнгө шар, амт гашуувтар нэг зүйл өвс); 3. ш и л ж с э н чин, үнэн, голын, дотно, пайз; **халуун зүрхний угаас** (чин зүрхний угаас); **халуун нөхөр** (дотно итгэлт нөхөр); **халуун амь** (жинхэнэ гэр бүлийн дотор, өөрсөд хоорондоо; *гэрийн дотор зургаан халуун амь);* **халуун зуур** (өөр хоорондоо, дотроо ,садан төрлийн дунд, улс аймаг дотроо; *харь газар үгээ бэхэл, халуун зууpаа эвээ бэхэл* з ү й р); 4. ичмээр, зовнимоор, зэвүүн хэцүү: **таних хүний нүүр халуун** (таних учир хэцүү, зэвүүн); **халуун нүүр** (улаан нүүр, яг нүүрээрээ); **халуун сэрэг** (эхэн дээр нь, шинэ дээр нь, тэр даруйд нь); **ямааны мах халуун дээрээ** (алив явдлын шинэ сэрэг дээр); ☆ **халуун чулуу долоох** ш и л ж с э н (хашир үзэх, бэрхийг өнгөрүүлэх).

ХАЛУУРАХ өвчний улмаас биеийн ердийн халуун нэмэгдэх; *ханиад хүрч халуурах.*

ХАЛУУРУУЛАХ халуурахын үйлдүүлэх хэв.

ХАЛУУТАХ улмаар халуун болох.

ХАЛУУТГАХ халуун болгох.

ХАЛУУТГУУЛАХ халуутгахын үйлдүүлэх хэв.

ХАЛУУХАН баахан халуун.

ХАЛУУЦАХ бие халуу оргиж эвгүй болох; *үстэй дээлтэй халууцаж байна; халууцаж хөлрөх.*

ХАЛУУЦУУЛАХ 1. халууцахын үйлдүүлэх хэв; 2. тойвтой, эвгүй санагдуулах; **чихий нь халууцуулах** (муу юм, бүтэхгүй явдал сонсогдуулах).

ХАЛХ I 1. халхлан хамгаалах хэрэгсэл; *нарны халх; галын халх* (зуухны наана тавих хавтгай халхавч мод); 2. х у у ч и р с а н бамбай, халхавч.

ХАЛХ II Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үндсэн хүн амын нэр; *халх монгол; ар халх; халх аялгуу.*

ХАЛХАВЧ 1. юмнаас халхлах хэрэгсэл, нөмөр; *нарны халхавч; салхинаас хамгаалсан халхавч барих;* 2. ш и л ж с э н хамгаалах, далдлах, түрээ барих зүйл: **халхавч хаалга** (хаалганы дотуур давхарлан хийсэн үүд).

ХАЛХАЙ хүний бие махбодоо гэнт халах буюу түлэгдэхэд уульхайлан хэлэх аялга, халагтай, халагцай, халцгай ,халахцай ч гэдэг, *халхай, яасан халуун юм бэ!*

ХАЛХАЙЛГАХ халхайхын үйлдүүлэх хэв.

ХАЛХАЙХ халхгар болох.

ХАЛХАЛЗАХ халхгар юмны байн байн хөдлөх.

ХАЛХГАНАХ халхгар юмны үргэлжлэн хөдлөх.

ХАЛХГАНУУЛАХ халхганахын үйлдүүлэх хэв.

ХАЛХГАР балхгар бүдүүн, элбэг хэлхгэр; *халхгар дээл.*

ХАЛХГАРДАХ хэтэрхий халхгар болох.

ХАЛХГАРДУУЛАХ халхгардахын үйлдүүлэх хэв.

ХАЛХДАХ аялан явахдаа халх аяны маягаар явах.

ХАЛХЖИХ 1. халх хэл аялгуутай болох; 2 халх заншилтай болох.

ХАЛХЛАГДАХ халхлахын үйлдэгдэх хэв.

ХАЛХЛАХ далдавчлан хаах, далдлах, харагдахгүй байлгах; *гэрэл халхлах; нүүрээ халхлах; алтан нарыг чалгаар халхалж болохгүй* з ү й р.

ХАЛХЛУУЛАХ халхлахын үйлдүүлэх хэв.

ХАЛХЦАЙ халхай, халагцай, халахцай; *халхцай! яасан халуун юм бэ?*

ХАЛХЧУУД халх хүмүүс.

ХАЛХШИХ халхын шинж байдалтай болох.

ХАЛЦ хүч нэмэгдүүлэх үг; *халц цохих; халц татах.*

ХАЛЦАРХАЙ халцарсан газар, үс ургамал зэрэг байхгүй болсон, зулгарсан газар; *халцархай нэхий; халцархай газар.*

ХАЛЦГАЙ I өвс, үсний тачир, зарим газартаа ургаагүй, халцархай; *халцгай үстэй нэхий; өвс нь халцгай ургасан газар.*

ХАЛЦГАЙ II халуун юманд санамсаргүй гэнт хүрэх мэтэд дуу алдан хэлэх аялга; *халцгай, ямар халуун юм бэ!*

ХАЛЦГАЙВТАР баахан халцгай.

ХАЛЦГАЙДАХ хэтэрхий халцгай болох.

ХАЛЦГАЙДУУЛАХ халцгайдахын үйлдүүлэх хэв.

ХАЛЦГАЙРАХ халцгай болох.

ХАЛЦГАЙРУУЛАХ халцгайрахын үйлдүүлэх хэв.

ХАЛЦГАЙТАХ улмаар халцгай болох.

ХАЛЦЛАХ халцрахад хүрүүлэх, халцгай болгох.

ХАЛЦМАЙ алц туухайгий нь билүүдсэн шагаа.

ХАЛЦРАХ үс, ургамал зэргийн зулгаран унах; *малгайн үс халцрав.*

ХАЛЧГАНАХ маш нимгэн хувцас зэргийн хөдлөх; *дан тэрлэгтэй халчганан явах.*

ХАЛЧГАНУУЛАХ халчганахын үйлдүүлэх хэв.

ХАЛЧГАР хувцас зэргийн зохисгүй нимгэн; *халчгар дээлтэй даарах.*

ХАЛЧГАРДАХ хэтэрхий халчгар болох.

ХАЛЧИЙЛГАХ халчийхын үйлдүүлэх хэв, халчийхад хүрүүлэх.

ХАЛЧИЙХ халчгар болох.

ХАЛЧИЛЗАХ халчгар юмны байн байн хөдлөх.

ХАЛЧИХ 1. өндөрхөн газрыг харан хасах; 2. мах зэргийн юмыг нимгэн болгон огтлох.

ХАЛШРАЛ халшрах үйлийн нэр.

ХАЛШРАЛГҮЙ халшрахгүй, бэрхшээхгүй, мятрахгүй.

ХАЛШРАХ бэрхшээх, түвэгшээх, зүрхших, эмээх, үл шийдвэрлэх; *халшраад уулзаж чадахгүй байв.*

ХАЛШРУУЛАХ халшрахын үйлдүүлэх хэв.

ХАЛЬС юмны дээгүүр буюу гадуур давхацлан тогтсон бүрээс, хөрс мэт зүйл; *өндөгний хальс; төмсний хальс; самрын ясны дотуурхи хальс;* **шар хальс** (арьс махны завсрын бүрхэвч).

ХАЛЬСДАХ хэтэрхий хальс болох.

ХАЛЬСЛАХ хальсыг хуулах.

ХАЛЬСЛУУЛАХ хальслахын үйлдүүлэх хэв.

ХАЛЬСРАХ хальс болох

ХАЛЬСРУУЛАХ хальсрахын үйлдүүлэх хэв.

ХАЛЬСТАХ улмаар хальстай болох.

ХАЛЬТ халти.

ХАЛЬТРАА халтиргаа; *хальтраатай зам.*

ХАЛЬТРАХ халтирах.

ХАЛЬТРУУЛАХ хальтрахын үйлдүүлэх хэв.

ХАЛЬТЧИХ байн байн халтирах.

ХАЛЬТЧУУЛАХ хальтчихын үйлдүүлэх хэв.

ХАМ цуг, нэгдсэн, нэгдмэл, хамт; хам явах; **хам үйлдвэр** (үйлдвэрийн олон салаа мөчрийг нэгтгэсэн газар).

ХАМАА 1. холбогдол; *юуны хамаа байх вэ; хамаа алга;* 2. журам, дэглэм; *хамаагаа алдах; хамаа намаагүй болох;* 3. садан төрлийн холбоо; *та нарын хооронд хамаа, сүлбээ бий юу?*

ХАМААГҮЙ 1. холбогдолгүй; *над хамаагүй; чамд хамаагүй, хаданд чимээгүй;* 2. зүйгүй, ёсгүй, журамгүй; *хүнийг хамаагүй загнаж яаж болно;* 3. эрээгүй, цээргүй, бүдүүлэг; *тэр чинь хамаагүй хүн шүү;* 4. хамаатан биш; *надтай хамаагүй хүн.*

ХАМААРАГДАХ *хамаарахын үйлдэгдэх* хэв.

ХАМААРАГЧ хамаарах үйл гүйцэтгэгч; хэлтсийн эрхлэгчийг хамаарагч.

ХАМААРАЛЦАХ хамаарахын үйлдэлцэх хэв.

ХАМААРАХ 1. хамаатай, холбоотой, холбогдолтой болох; *энд байгчдад бүгдэд нь хамаарна;* 2. өөр албаная буюу эзгүй байгаа албан тушаалтныг орлох; *хамаарсан элчин сайд.*

ХАМААРАХГҮЙ хамаарч холбогдох зүйлгүй.

ХАМААРГАХ хамаарахад хүргүүлэх, хамаарууулах.

ХАМААРУУЛАХ хамаарахын үйлдүүлэх хэв, холбогдуулах, оролцуулах.

ХАМААРХАХ хамаатай болох, холбогдолтой болох гэж хичээх.

ХАМААРХУУЛАХ хамаарахын үйлдүүлэх хэв.

ХАМААСАХ хамаатан болохыг хичээх.

ХАМААСУУЛАХ хамаасахын үйлдүүлэх хэв.

ХАМААТАЙ 1. холбогдол учир бүхий; *энэ хэрэг чамд хамаатай нь мэдээж;* 2. холбогдол учиргүй; *миний явдал чамд ямар хамаатай юм бэ;* 3. садан төрөл; *энэ хүн надтай хамаатай хүн шүү.*

ХАМААТАН садан төрлийн хүмүүс; **хамаатан садан, төрөл хамаатан** х о р ш.; *миний хамаатан олон; тэр чинь бидэнтэй холын хамаатан болох юм.*

ХАМАГ бүгд, бүх, байдаг, байгаа; *хамаг амьтан; хамаг төрөлхтөн; хамаг малаа хураан авчрав; хамаг явдлаа ярих; хамаг чадал хамаг хүч; хамаг аргаа хэрэглэх;* **хамгийн** (бүгдийн, бүхний, онцгой, туйлын; *хамгийн түрүүн; хамгийн сайн; хамгийн бага; хамгийн адаг).*

ХАМАГДАХ хамахын үйлдэгдэх хэв.

ХАМАГЧ I малын хамарт дөрөлсөн, дөр уях гогцоо; **дөр хамагч** х о р ш..

ХАМАГЧ II хамдаг хэрэгсэл; *хамагч машина.*

ХАМАГЧЛАХ 1. малын хамарт хамагч хийх; 2. эрхшээлдээ хураах.

ХАМАГЧЛУУЛАХ 1. хамагчлахын үйлдүүлэх хэв; 2. бусдын эрхшээлд хэтэрхий автагдах.

ХАМАЛЦАХ хамахын үйлдэлцэх хэв.

ХАМАЛЦУУЛАХ хамалцахын үйлдүүлэх хэв.

ХАМАР 1. үнэрийн сэрэгдэхүүнийг мэдрэх эрхтэн; **хамар хоншоор** х о р ш.; **хамрын багана** (хамрын хоёр нүхний хоорондох ташаалсан тулгар); **хамрын нүх** (хамрын сүв, үнэр үнэртэх, амьсгал авах орон); **хамар хатуу** (үхэр тэмээ зэргийн дөр бурантгаас татахад авд дийлдэхгүй нь); **хамрын тамхи** (хамраар үнэрлэж татах нунтаг тамхи); ☆ **хамар өвчин** (морь элжиг зэргийн битүү туурайт амьтанд тохиолдох нэгэн зүйл халдварт өвчин); 2. хашаа байшин, сав хэрэгслийг дундуур нь таслах хана; *хашааны хамар; хамар барих; цонхны хамар;* 3. залгалдуулан барьсан хашаа; *хамар хашаа; баруун зүүн хамартаа айлтай;* 4. бичиг дэвтрийн нэгэн хуудас; *нэг хамар хуудас; гурван хамар бичиг;* 5. гүдгэр, хөтөл; *тэр хамар дээгүүр давахад харагдана;* **гутлын хамар** (гутлын хушуу): **далны хамар** (амьтны дал ясны тууш сэрвэн яс); 6. нумын гичрийн үзүүрт заадаслан хийсэн эвэр зүйл.

ХАМАРДАЙ борх.

ХАМАРДАХ хамраас барих, татах.

ХАМАРЛАХ I юманд хамар хийх; *хашаа хамарлах.*

ХАМАРЛАХ II уулын хамрыг даган явах; *тэр уулыг хамарлаж яваарай.*

ХАМАХ 1. юмыг харамж, цуглуулан хураах; *өвс хамах; хог хамах;* 2. ш и л ж с э н бүгдийг хураан авах; *хамж аваад явжээ.*

ХАМБА I шашны ёсны сүм хийдийн хэргийг тэргүүлэн удирдах хүний тушаалын нэр; *хамба лам.*

ХАМБА II: **хамба торго** том дугуй хээтэй нэгэн зүйл торго; **хамба хээ** (торгоны том дугуй хээ); **хамба хилэн** (нявталхан тэгш үстэй хилэн); **хамба шарилж** у р г а м а л (шарилжийн нэг зүйл, эмнэлэгт хэрэглэнэ).

ХАМБИЛ у р г а м а л гаймуу ногооны адил навчтай, иш салаа нь ногоон, цайвар шар цэцэгтэй, хонгорцог нь хавтгай, үр нь монгол амуугаас арай жижигхэн болоод уртхан нэгэн зүйл ургамал.

ХАМГААЛАГДАХ хамгаалахын үйлдэгдэх хэв.

ХАМГААЛАГЧ хамгаалах үүрэг гүйцэтгэгч; *бие хамгаалагч; гал хамгаалагч.*

ХАМГААЛАЛ хамгаалах үйлийн нэр; **харгалзал хамгаалал** х о р ш.; *хамгаалал тавих; хамгаалалтай явах.*

ХАМГААЛАЛТ хамгаалал бий; **хадгалалт хамгаалалт** х о р ш.; *усны хамгаалалт; цахилгааны хамгаалалт.*

ХАМГААЛАЛТГҮЙ хамгаалах юмгүй; *арчлалт хамгаалалтгүйгээс осол гардаг.*

ХАМГААЛАХ 1. сэргийлж сахих, харгалзан сахих; *гал түймрийн аюулаас хамгаалах; эрүүлийг хамгаалах; салхинаас хамгаалах; биеэ хамгаалах;* 2. өмөөрөх, хаацайлах; *өмгөөлөн хамгаалах.*

ХАМГААЛУУЛАХ 1. хамгаалахын үйлдүүлэх хэв; 2. хамгаалагдах.

ХАМГАЛЗАХ баахан хамгаалах.

ХАМГАР у р г а м а л нэг зүйл зэрлэг сонгино.

ХАМЖАА хамжих нь, хамсаа, дэмжлэг; **хамжаа хамсаа** х о р ш.; *хамжаа болох.*

ХАМЖИЛЦАХ хамжихын үйлдэлцэх хэв; *хүдаг ухахад нь хамжилцаж өгөв.*

ХАМЖИЛЦУУЛАХ хамжилцахын үйлдүүлэх хэв.

ХАМЖИХ элбэх, хавсрах, хамтран хийх, хамсах; *хэд хэдэн хүн хамжиж барьсан байшин; хамжиж авсан хашаа.*

ХАМЖЛАГА х у у ч и р с а н ноёд тайж нарт захирагдсан ард иргэд, сумын эрд үл ороллоно; *хамжлагатай тайж нар, албат хамжлагаа албадан зарцалж суудаг байв; хамжлагын боол; хамжлагын өрх; хамжлагын хүн.*

ХАМЖЛАГАГҮЙ хамжлагын ардгүй, хохь; *хамжлагагүй тайж.*

ХАМЖЛАГАТ хамжлагатай; *хамжлагат ёсыг устгаж ардын төрийг байгуулав.*

ХАМЖЛАГАТАЙ хамжлага бүхий; *хамжлагатай тайж.*

ХАМЖУУЛАХ хамжихын үйлдүүлэх хэв.

ХАМНИГАН Манж хэлтэнд багтах нэгэн аймаг.

ХАМРАХ олныг нийтээр дайрах, нийтээр багтаан хамж аваачих; *нийтээр нь хамрах; сургуульд хамран оруулах.*

ХАМРУУЛАХ хамрахын үйлдүүлэх хэв.

ХАМСАА үйл явдалд хань хамжаа болох нь; хань **хамсаа** х о р ш.; *эдний хань хамсаагий нь сайн мэдэх хэрэгтэй.*

ХАМСАХ хамжих, хавсах, хамтрах; *ажлаа хамсаж хийх; хамсаж хоолоо бэлтгэх.*

ХАМСРАХ хамтрах, хавсрах, хамсах, хамжих.

ХАМСРУУЛАХ 1. хамсрахын үйлдүүлэх хэв; 2. хамтруулах.

ХАМСУУЛАХ. 1. хамсахын үйлдүүлэх хэв; 2. хамааруулах.

ХАМТ 1. цуг, ний; *хамт явах; нэгэн хамт; хамтын хөдөлмөрийн ашигтай тал; эв хамт ёс; хамтын хүчээр; хамтын гэрээ;* 2. сацуу; *намайг гэрээс гарахын хамт ширүүн бороо оров; харахын хамт танив;* 3. хажуугаар, зэрэгцээгээр; *ажиллахын хамтаар суралцах; сурахын хамтаар ажиллах.*

ХАМТАД хамт, хамтаар.

ХАМТАТГАЛ хамтатгах үйлийн нэр.

ХАМТАТГАХ хамтдахын үйлдүүлэх хэв, хамт болгох, хамт гүйцэтгэх, нэгэн зэрэг гүйцэтгэх; *хоёр зүйлийн зарлалыг хамтатгах.*

ХАМТАТГУУЛАХ хамтатгахын үйлдүүлэх хэв.

ХАМТДАХ хамт болох; ☆ **хамтдах цэцэг** у р г а м а л (цэцэг түрүүтэхэд дээд хагас цагаан, доод хагас улаан, намар нахиална, үдэш зангирна, салхинд тус тус салдаг нэгэн зүйл цэцэг).

ХАМТЛАХ хамтатгах, нэгэн хамт болгох; *нэр хамтлах.*

ХАМТЛУУЛАХ хамтлахын үйлдүүлэх хэв.

ХАМТРАГЧ хамтарсан хүмүүс.

ХАМТРАЛ хөдөө аж ахуйг хамтын хүчээр хөгжүүлэхийн тул хөдөлмөрчин тариачдын нэгдсэн нийгэм журмын хэлбэртэй хөдөлмөрийн нэгдэл; ***тэргүүний хамтрал; саят хамтрал.***

ХАМТРАЛЖИХ хамтралтай болох.

ХАМТРАЛЖУУЛАХ хамтралжихын үйлдүүлэх хэв.

ХАМТРАЛЧ хамтралын гишүүн.

ХАМТРАХ нийлэх, хамт болох, нэгдэх; *хамтарсан хүчээр ажлыг бүтээх; хамтран айл гэр болох.*

ХАМТРУУЛАХ хамтрахын үйлдүүлэх хэв.

ХАМУУ маш их загатнах, арьсны халдварт өвчин; *хамуутай тэмээ шиг шөргөөх; хуурай хамуу; нойтон хамуу;* **нойтон хамуу шиг** (авд салдаггүй).

ХАМУУЛАХ 1. хамахын үйлдүүлэх хэв; 2. хамагдах.

ХАМУУР хамах зэвсэг; *өвсний хамуур; хогийн хамуур.*

ХАМУУРАХ хамуу өвчин тохиох; *тэмээ хамуурах.*

ХАМУУРУУЛАХ хамуурахын үйлдүүлэх хэв.

ХАМУУТАЙ хамуу бүхий; *хамуутай тэмээ.*

ХАМХ: хамх цохих цохиж хамхлах.

ХАМХАГ ургамал хавар буюу зуны эхээр хуучин үрээс үндэслэн ургаад намар цагт гүйцэт боловсрох нэгэн аймаг ургамлын нэр, зүйл ялгал ба дүр байдал олон өөр.

ХАМХИГДАХ хамхихын үйлдэгдэх хэв.

ХАМХИУЛАХ 1. хамхихын үйлдүүлэх хэв; 2. хамхигдах.

ХАМХИХ хавсран битүүлэх, хаах; *ам хамхихгүй ярих; үүдээ хамхиж орхих.*

ХАМХЛАХ хэмхлэх, няцлах.

ХАМХРАХ хэмхрэх, няцрах.

ХАМХУУЛ ургамал талд ургах бөгөөд хатахдаа үндэснээсээ салан, бөөрөнхий бут болж салхинд хол газар бөмбөрөн хийсэх өвс; *хамхуул хийсэх.*

ХАМХЧИХ хэмхчих, эвдлэх, байн байн хамхлах.

ХАМШАА хавтгай, налчгар хамар; *хамшаа хамартай хүн.*

ХАМШГАР 1. хэвийн жишээнээс нимгэн хавтгай; *хамшгар хамар; хамшгар хайрцаг;* 2. шүдгүй учир эрүү дээш өргөгдсөн нь; *хамшгар эрүүтэй.*

ХАМШИЙЛГАХ хамшийхын үйлдүүлэх хэв.

ХАМШИЙХ хамшгар болох.

ХАН I хуучирсан аймаг мужийг ахалсан хүнд олгох цол; *Түшээт хан; Сэцэн хан; Сайн ноён хан;* **хан гарди** (үлгэр домогт гардаг гайхамшиг чадалтай, маш том биетэй шувуу; *жигүүртний хан, хан гарди гэж хэлэлцдэг*); **хан хас** (эрдэнийн чулуу, хасын хамгийн дээд зэрэг нь мөн).

ХАН II: **хан төмөр** ургамал зөөлөн улингар газар үетэн ургадаг, үе бүрээс зүг зүг тийш хандсан салаа гарна, навч нь шувууны таваг хэлбэртэй бөгөөд том, ногоон цагт нь мал бараг иддэггүй, гандсан хойно нь мал идэдэг нэгэн зүйл ургамал.

ХАН III: **хан хийх** 1. төмөрлөг зэргийн юмнаас гарах чимээ; *төмрийн дуу хан хийв;* 2. юмны үнэр ханхлан үнэртэх; *саримсаг хан хийв.*

ХАНА (Н) 1. гэрийн туургаар босгон барих тор мод; *арван таван толгойтой хана; дөрвөн ханатай гэр; ханын ёроолд төрж, хадны ёроолд үхэх* зүйр; **ханын ам** (ханын нийлэлдэх уулзар); **ханын нүд** (дэлгэсэн ханын дөрвөлжин нүхнүүд); **ханын толгой** унины бөгсийг тавьж тогтоох жижиг ацнууд): **ханын үдээр** (ханыг товчлон үдэх бэхлээс); **ханын үдээс** (ханыг үдээрээр үдсэн нь); **ханын шийр** (ханын газарт тулж тогтох доод этгээд); ☆ **ханын сонин** (хана туурганд хадах жижиг сонин бичиг); **ханан хээ** (ханын нүд мэт дөрвөлжин нэг зүйл хээ); **ханын цаг** (хананд хадах том цаг); **ханан хад** (эгц өндөр хад); 2. барилгын туурга; *байшингийн хана;* 3. барилгыг шавардахад шаврыг тогтоохын тул туурганд барьж хадах сараалж; *хана хадах,* 4. сур, шагаа харвахад өрөх өндөр өрөг; *хана харвах;* 5. шувууны жигүүрийн эхний сод өдний дараа ургасан өд; *хана өд.*

ХАНААХ ханахын үйлдүүлэх хэв.

ХАНАГАР 1. лут, мундаг, том; *ханагар имьтан; ханагар гэр;* 2. хангалуун, хангамжтай, элбэг дэлбэг; *ханагар айл.*

ХАНАГДАХ ханахын үйлдэгдэх хэв.

ХАНАЙЛГАХ ханайхын үйлдүүлэх хэв.

ХАНАЙХ ханагар болох, хангамжтай байх.

ХАНАЛ 1. ханах үйлийн нэр; *ханалтай; ханалыг мэдэхгүй;* 2. шунал; *ханал нь хэтэрсэн; ханал нь барагдахгүй.*

ХАНАЛГҮЙ хэтэрхий шунахай, шунал ихтэй, сэтгэл үл ханах.

ХАНАЛЗАХ ханагар байдал гаргах.

ХАНАМЖ хангамж.

ХАНАМЖГҮЙ хангамжгүй.

ХАНАМЖТАЙ хангамжтай.

ХАНАНЦАР алив хөндий эрхтний бүрхэвч, хажуу этгээд; *ходоодны хананцар; судасны хананцар.*

ХАНАРАХ 1. эгнэж зэрэгцсэн юмс нэг тийш хазайх, унах; *хашаа ханарч унах; шүд ханарах;* 2. дурлан дагах; *улс төрд ханаран дагах;* 3. зэргээр дайрах; *жагсагчид ханаран дайрах.*

ХАНАРУУЛАХ ханарахын үйлдүүлэх хэв.

ХАНАХ I 1. эгээрэл хүслийг хүрэлцтэл, дүүртэл олох, эдлэх; *сэтгэл ханах; хүсэл ханах; үзэж ханах; нойр ханах;* 2. ундаасаа гарах; *ууж ханах; ханах цадах;* 3. алив эргүүлэх юмны угтаа тултал гүйцэд эргэх; *ханатал эргүүлэх;* ☆ **ханасан уусмал** (уусах зүйл нь хэт их уусмал).

ХАНАХ II эмчлэх зорилгоор судсыг хатган цоолж цусыг гаргах.

ХАНАЧЛАХ хана мэт нүд гаргаж үйлдэх; *ханачилж оёх; ханачилж ширэх; ханачилж хөдах.*

ХАНБА хамба.

ХАНГА булга, үнэг зэрэг үстийн арьсыг тэлэх модон хэрэгсэл.

ХАНГАГДАХ хангахын үйлдэгдэх хэв.

ХАНГАДАХ 1. үстийн арьсыг хангаар тэлэх; 2. арьс ширийг хянгар чулуу мэтээр харан элдэх.

ХАНГАДУУЛАХ хангадахын үйлдүүлэх хэв.

ХАНГАЙ 1. уул нуруу, ой хөвчтэй, олон тооны гол горхи, нууртай, хөвд өвсөрхөг ургамалтай, зөөлөн сэвсгэр хөрстэй, сэрүүн улиралтай газар; *хангай газар; хангайн ургамал; хангай говийн завсрын нутаг; Хангай говийн хооронд Халхын уудам нутаг, хар бага наснаас хөндлөн гулд давхисан газар* (Д. Нацагдорж): ☆ **хангайн хар төмс** ургамал хад, аса, ой шугуйгаар ургадаг нэг зүйл спорт ургамал, ойм хэлбэртний ангид багтана); 2. газар, дэлхий; **хангай дэлхий** хорш.; *хангай дэлхийн баялаг;* 3. цээрлэсэн чоно; *хангай өлзий байна уу?*

ХАНГАЛ I ардаг, танхи, эмнэг, догшин; *хангал үрээ; хангал хүн.*

ХАНГАЛ II хангалт.

ХАНГАЛТ хангах үйлийн нэр; *хангалт сайтай; хангалт муутай.*

ХАНГАЛТГҮЙ хангамжгүй, ханамжгүй, муу хангасан, тохиромжгүй, хангалт муутай; *төлөвлөгөөт ажлыг биелүүлэх талаар маш хангалтгүй байна; хангалтгүй дүн.*

ХАНГАЛТТАЙ хангалт бүхий, хангамжтай; *малын хашаа хангалттай барьсан байна.*

ХАНГАЛУУН 1. сэтгэл ханасан, сэтгэл дүүрэн, шуналгүй зантай; *сэтгэл хангалуун байх;* 2. хүсэх, горилохгүй, тоохгүй, тоомсорлохгүй зантай; *юуг ч тоохгүй их л хангалуун явав.*

ХАНГАМЖ ханамж, хангасан хэмжээ. байдал.

ХАНГАМЖГҮЙ хангалтгүй, хангалт муутай; *хангамж муутай; хангамжаар сайн.*

ХАНГАМЖЛАХ ханамжтай болгох, хангалттай болгох.

ХАНГАМЖТАЙ хангамж бүхий, хангалттай.

ХАНГАРАХ сум зэвний арьсан дээгүүр халти шүргэн гарах; *сум хангарах.*

ХАНГАХ ханахын үйлдүүлэх хэв; *дутагдалтай зүйлээр хангах; ном дэвтрээр хангах; хүслийг хангах; төлөвлөгөөг хангаж биелүүлэх.*

ХАНГИ янги, данги; **ханги янги, ханги данги** хорш.; *ханги хөлдөх; ханги цохих; ханги элдэх.*

ХАНГИЛ: хангил хавцгай уулын нүцгэн, хадтай орой, хавцгай.

ХАНГИНАХ 1. төмөрлөгийн зүйл, хөгжим, хүн амьтны нарийн жингэнэсэн дуу сонсдох; **хангинах жингэнэх** хорш.; *хөгжим хангинах; хонх хангинах; хүүхдийн дуу хангинах;* 2. зэмлэх, зандрах; 3. шилжсэн хүйтэн жаврын хүчтэй болох; *хүйтэн хангинах;* 4. ханхлан үнэртэх; *өмхий хангинах;* 5. янгинах; *гар хангинаж өвдөөд унтуулсангүй;* 6. гавшгай, хөдөлгөөнтэй; *хангинасан сурхий хүн байна билээ.*

ХАНГИНУУЛАХ хангинахын үйлдүүлэх хэв.

ХАНГИНУУР 1. хангинасан дуутай, цангинуур; **хангинуур сүх** (нимгэн хавтгай сүх); 2. гавшгай, хөнгөн хөдөлгөөтэй; *хангинуур хүн.*

ХАНГИР: хангир жингэр хийх төмөр мэтийн юмны хангинан жингэнэн дуугарах; *хонх хангир жингэр хийн дуугарч байв.*

ХАНГИРЦАГ богт чөмөгний үзүүрийн бяцхан яс.

ХАНГИС хоёр үзүүртээ сацагтай уртхан алчуур; ☆ **хангис чингэс хийх** (хангир жингэр хийх).

ХАНГУУЛАХ 1. хангахын үйлдүүлэх хэв; 2. хангагдах.

ХАНД юмыг шингэн юманд чанаж дарж идээшүүлэн шимийг шингээж авсан хорхог; *ханд эм; цайны ханд; иодын ханд.*

ХАНДАХ зүглэх, чиглэх, нэгэн зүг рүү болох; *эсрэг хандах; түүний зүг хандах; олны зүг хандаж хэлрүүн.*

ХАНДГАЙ а м ь т а н бугын нам, хөхөөр өсөх ац туурайтны төрөл, бие том, өргөн хавтгай эвэртэй, сахлаг үстэй, хүрэн бор өнгөтэй гөрөөс.

ХАНДЛАГА хандах чиглэл; *зөв хандлага; буруу хандлага.*

ХАНДЛАГДАХ хандлахын үйлдэгдэх хэв.

ХАНДЛАХ ханд болгох, удаан буцалгаж шимийг шингээн авах; *эм хандлах; цай хандлах.*

ХАНДЛУУЛАХ 1. хандлахын үйлдүүлэх хэв; 2. хандлагдах.

ХАНДРАХ ханд болох, идээшиж өтгөрөх.

ХАНДУУЛАХ хандахын үйлдүүлэх хэв, зүглүүлэх, чиглүүлэх; *зүүн тийш хандуулах; мод руу хандуулах; зөв замд хандуулах.*

ХАНДШИХ ханд шинжтэй болох.

ХАНЖААР хантааз.

ХАНЖААРЛАХ ханжаар өмсөх.

ХАНЗ байшин буюу гэрт хагас талыг эзлүүлэн, суух, хэвтэхэд зориулж хийсэн хөмрөг; *халуун ханз; ханзтай байшин;* **ханзан ширээ** (намхан том ширээ; *ханзан ширээ хавчуулж суугаад чин цай уухаар зүүдлэв* (ардын дуу).

ХАНЗАРХАЙ ханзарсан газар; *гутлын ханзархай.*

ХАНЗЛАГДАХ ханзлахын үйлдэгдэх хэв.

ХАНЗЛАХ I 1. юмыг задлах, онгойлгох; *дээл ханзлах; лүүтэй архиа ханзлах;* 2. татаж урах; *цамцаа битгий ханзалж орхи.*

ХАНЗЛАХ II өвдөж босч чадахгүй хэвтэх; *ханзлан хэвтэж бий учир ажилдаа очиж чадахгүй байна.*

ХАНЗЛУУЛАХ 1. ханзлахын үйлдүүлэх хэв; 2. ханзлагдах.

ХАНЗРАХ 1. оёдлоороо урагдах, тасрах; *гутлаа ханзартал явжээ;* 2. гагнаас, ширээс, заадас зэргээрээ цуурах, ангайх; *авдар ханзрах; данхны цорго ханзрах;* 3. хаврын улиралд цас хайлж эхлэх; *цас ханзрах.*

ХАНЗРУУЛАХ ханзрахын үйлдүүлэх хэв.

ХАНИАД 1. амьсгалын сүв үрэвсэн халуурах, сочмог халдварт өвчин: **ханиад томуу** х о р ш.; *ханиад хүрэх; ханиадны эм;* 2. ханиалгах нь; **бүгшүүлдэг ханиад** (ихэнхдээ хүүхдэд тусах халдварт өвчин); **хуурай ханиад** (цэр үл ховхрон ихэд ханиалгах ханиад).

ХАНИАДАН: инээдэн ханиадан инээдэм.

ХАНИАЛГА (Н) ханиах үйлийн нэр; *ханиалганы эм;* **хуурай ханиалга** (хуурай ханиад).

ХАНИАЛГАХ ханиахын үйлдүүлэх хэв, ханиахад хүрүүлэх, байн байн ханиах.

ХАНИАХ амьсгалын мөр өвчлөхөд амьсгалыг огцом хүчтэйгээр хахиран гаргах; *ханиахад уух эм; хөхүүлж ханиах; хуурай ханиах ханиахад хамаг бие доргидог.*

ХАНИГҮЙ 1. нөхөр, ижилгүй, ганцаар; 2. ш и л ж с э н хосгүй, тасархай, онцгой.

ХАНИЛАХ 1. нөхцөх, амраглан дотнолох, эр эм бололцох; *ханилан суух; ханилсан нөхөр; ханилбал өтөлтлөө, хайрлавал өсгөтлөө з ү й р;* 2. хамт явах, зорчих; *ханилан явах.*

ХАНИЛУУЛАХ ханилахын үйлдүүлэх хэв,

ХАНИН хайдаа.

ХАНИРХАГ ханьсаг.

ХАНИРХАХ 1. хань болгохыг эрмэлзэх, хань татах; 2. ханьтайдаа бардах.

ХАНСАХ арьсны үсийг хусах, зүйлэн арилгах.

ХАНСИЙ ханш IV.

ХАНТААЗ гадуур өмсөх, ханцуйгүй цээжмэг хувцас, ханжаар; *хошмогтой хөх торгон хантааз.*

ХАНТАЙРАХ 1. морины жолоо буюу цулбуурыг гэдрэг сойж эмээлийн бүүрэгт эсвэл ганзагаар бэхлэх; *морио хантайрах;* 2. тэгнэсэн ачааг дээгүүр нь холбон хэдэрч уях; 3. сайн бэхэлж туших.

ХАНТАЙРГА 1. хантайрсан нь; 2. ачааны тэнгийн дээгүүр холбож хэдэрсэн оосор; 3. саадаг зүүх оосор; 4. морины тушаа.

ХАНТАЙРУУЛАХ хантайрахын үйлдүүлэх хэв.

ХАНТРАГА хантайрга.

ХАНТРАХ хантайрах.

ХАНТРУУЛАХ хантрахын үйлдүүлэх хэв.

ХАНУУЛАХ 1. ханахын үйлдүүлэх хэв; 2. ханагдах.

ХАНУУР судас хатгаж цоолох, ханах хэрэгсэл; *хутган хануур;* **хануур жад** (нарийн хурц үзүүртэй жад); **хануур зэв** (ханах, хатгахад зориулж хийсэн хутга); **хануур хорхой** амьтан (ихэнхдээ цэнгэг усанд орших, хагас шимэгч буюу махчин шавьж, ханах өвчинд хэрэглэнэ).

ХАНХАЙ I 1. хогшил юм тавиагүй, хөндий, хоосон; *ханхай гэр; ханхай авдар;* 2. ачаагүй; **ханхай эмээл** (ачааны эмээл); **ханхай тэрэг** (ачаагүй хоосон тэрэг).

ХАНХАЙ II шатрын тэрэг.

ХАНХАЙЛАХ ханхай болгох; *гэр ханхайлах.*

ХАНХАЙЛГАХ ханхайхын үйлдүүлэх хэв, ханхгар болгох.

ХАНХАЙХ I ханхар том болох; *бөхийн том цээж нь ханхайж байх харагдав.*

ХАНХАЙХ II ханхай болох.

ХАНХАЛЗАХ 1. ханхгар юмны байн байн хөдлөх; *өргөн цээж ханхалзаж байв;* 2. шилжсэн бардам авир гарган цээжээ хөдөлгөх; *архинд согтож хэнхдэгээ дэлгэн ханхалзаж явав.*

ХАНХАЛЗУУЛАХ ханхалзахын үйлдүүлэх хэв.

ХАНХАР ханхгар, том; *ханхар цээжтэй бөх; ханхар гэр.*

ХАНХГАР хэвийн жишээнээс өргөн, том, янхигар, ханхар; *ханхгар цээж; ханхгар ат.*

ХАНХГАНАХ ханхгар юмны үргэлжлэн хөдлөх.

ХАНХИАЛ 1. ханхир, ханхгар; *ханхиал том эр;* 2. ахиад, хэвлүүн; *ханхиал хүүхэд;* 3. бие богино бахимхан; *ханхиал биетэй морь.*

ХАНХИГАР янхир, янхигар, данхигар, том.

ХАНХИЙХ ханхигар болох, янхийх, данхийх.

ХАНХИЛАХ ханхлах, үнэртэх; *муухай үнэр ханхилах.*

ХАНХИР ханхар, том, янхигар, янхир.

ХАНХЛАХ үнэрийн их л үнэртэх, анхилах, ханхилах; *цэцгийн үнэр ханхлах; архи ханхлах.*

ХАНХЛУУЛАХ ханхлахын үйлдүүлэх хэв; *саримсаг ханхлуулах.*

ХАНЦУЙ дээл хувцасны гарт өмсөх хэсэг; *өргөн ханцуйтай дээл;* **мухар ханцуйтай** (нударагагүй); **ханцуй шамлах** (ханцуйгаа дотогш эргүүлэх): **ханцуй сажих** (гар хаялах); ☆ **ханцуй өөш** (загас агнах нэг зүйл тор).

ХАНЦУЙЛАХ 1. ханцуйг гарт өмсгөх; 2. юмыг ханцуй дотор агуулах; *арчуураа ханцуйлах;* 3. шилжсэн юмыг хулгайлан авах; *ханцуйлдаг хүн.*

ХАНЦУЙЛУУЛАХ ханцуйлахын үйлдүүлэх хэв.

ХАНЧИН төвд гутал.

ХАНЧИР 1. амьтны цоройн хоёр этгээдийн бүлх хальсаар бүтсэн хэсэг; 2. өрөөл гар-татуу өвчтэй; *ханчир хүн.*

ХАНШ I үнийн тогтоол; *мөнгөний ханш; зах зээлийн ханш; ханш буурах.*

ХАНШ II: **ханш нээх** сарны зурхайн ёсны жилийн хорин дөрвөн улирлын хаврын дунджийг заах үе, нарны зурхайн дөрөвдүгээр сарын эхний арав хоногийн дотор тохиолдоно.

ХАНШ III найз сайтай, эвлэгхэн, нийлэмжтэй, тусч зантай; *ханштай нөхөр; ханш муутай залуу.*

ХАНШ IV нэгэн зүйл маш нимгэн торгомсог эдийн нэр.

ХАНШААР хамрын уг; ☆ **ханшаарын төмөр** (хазаарын чимэг).

ХАНШГҮЙ нийц, найз, ханилгаа муутай.

ХАНШТАЙ нийц, найз, нөхөр сайтай; *ханштай хүн; ханштай хүүхэн.*

ХАНЬ нөхөр, хамсаа ,хамт явагч; *нэг насны хань; хань болох; хань нөхөр; ханаа муутай бол малаа алдахын тэмдэг, хань муутай бол хүнээ гээхийн тэмдэг* з ү й р; **хань татах** (бусдыг хань нөхөр болгохын тул биедээ татах, хамтрах); **замын хань** (тусгай зорилгоор түр зуур хань болгосон хүмүүс); **дотнын хань** (маш итгэмжилсэн нөхөр).

ХАНЬС доргоны зулзага.

ХАНЬСАГ хань эрэмтгий, хань мөрөөдөгч

ХАНЬСАХ ханилах, хань болох.

ХАНЬЦАХ ханилах, нөхөрлөх, эр эм болоцох; *ханьцан суусан нөхөр.*

ХАНЬЦУУЛАХ ханьцахын үйлдүүлэх хэв.

ХАНЬШААЛГАХ ханьшаахын үйлдүүлэх хэв.

ХАНЬШААХ хань татах, хань болгохыг эрмэлзэх.

ХАР 1. цагааны эсрэг, хөө, нүүрсний өнгө; *хар будаг; хар савхин гутал; хар гэртээ хаан, бор гэртээ богд* з ү й р; **ертөнцийн гурван хар** (тостойгоос тогоо хар, билигтэйгээс бэх хар, амттайгаас архи хар буюу, айраг цагаанаас ɪарч байвч архи нэг хар, арчиж зүлгэж байвч тогоо нэг хар, алт мөнгөөр чимж байвч үс хар); **хар бор** (харавтарт бяцхан цайвар өнгө хольцолдсоны нь): **хар хээр** (харавтарт улаавтар буюу шараавтар өнгө бяцхан хамсалдсан зүс); **хар хүрэн** (гүн хүрэн); **хар хөх** (гүнхөх); **хар саарал** (а. харавтарт цайруу хольцолдсон өнгө; б. морь малын тод хараас бяцхан бүдэх хар зүсэм; *хар саарал морь*); **хар ногоон** (хард ногоон өнгө холилдсон өнгө); **хар хөө** (гай уршиг чирэх юм); **хар цай** (а. нэгэн зүйл цай, шахмал задгай хоёр зүйл бий; б. сүлээгүй цай); **хар хусам** (түлэгдэж харалсан хусам); **хар талх** (хөх тарианы гурилын талх); **хар гурил** (хөх тарианы гурил); **хар мах** (өөхгүй мах); **хар бурам** (чихрийн ургамлын чихрийг боловсруулан аваад үлсэн шаарыг хорхоглон өтгөрүүлж хийсэн **нэгэн** зүйл чихэрлэг, зэрлэг ургасан зэгс хулсны түрүүнээс гарах нь бий); **хар тос** (олсны үрийг шахаж авсан тос); **хар архи** (нэгэн зүйл архи); **хар хөрс** (тариалан тарихад тохиромжтой бор хөрс); **хар шороо** (хар хөрсний шороо); **хар газар** (цасгүй газар); **хар чийг** (үдэш, шөнийн цагт буух чийг); **хар ус** (ширгэхгүй, дороос ундрага бүхий тогтмол ус); **хар хөлс** (биеэс дааварлан гарах **их** хөлс; *хар хөлс нь асгарах*); **хар тугалга** (хорголж, зөөлөн, хүнд, хөхөвтөр өнгийн төмөрлөг); **хар хас** (бараан хар өнгөтэй нэгэн **зүйл** хас чулуу): **хар байван** (нэгэн зүйл хужир); **хараар наадах** (шатрын харыг эзэмшин наадах); **хар лам** (Хрестосын шашны лам); **хар тамхи** у р г а м а л (а. намуу цэцгийн төрөл, урт бөгөөд том навчтай, шар буюу улаан цэцэгтэй ургамал; б. мөн ургамлын гүйцэд боловсроогүй байхад огтолж сүүн мэт шүүсийг авч хатаасныг); **хар цагааны газар** (хар цагаан юм ялгагдах хэмжээний газар); **хар дэл** (дэл гэдэг ургамлын үрийн хары нь); **хар нэрс** (нэгэн зүйл жимсгэнэ); **хар шарилж** у р г а м а л (шарилжны дүрсийн нэгэн зүйл); **хар чийр** у р г а м а л (гоньдын нэгэн зүйл); **хар даль** у р г а м а л (далийн төрлийн ургамал); **хар маалинга** у р г а м а л (хальсны өнгө хар нэг зүйл маалинга); **хар майлс** (өм мод); **хар балчиргана** у р г а м а л (агшиганын өөр нэр); **хар зээргэнэ** (морин зээргэнийн өөр нэр); **хар мод** (харгай мод); **хар мөөг** у р г а м а л (доторхи салбан нь хатахдаа хар болдог дэлбэгэр мөөг): **хар агар** у р г а м а л (цайвар, хөхөвтөр өнгөтэй, сайхан үнэртэй мод); **хар хус** у р г а м а л (хүсны навчтай адил болоод ширүүн, дурс дарсайлцан ургасан, мах судал нарийн нягт, өнгө харавтар улаавтар хоёр зүйл байдаг); **хар хамаг, хар хамхаг** у р г а м а л (элсэрхэг улингар газарт ургах бутархаг ургамал, өргөст хамхаг ч гэдэг); **хар шаваг** у р г а м а л (шавгийн төрлийн нэгэн зүйл бут, елхэндэг ч гэнэ); **хар гүйлс** у р г а м а л (модноос ургадаг, түүхийдээ ногоон, боловсромогц шаравтархан болно, утаагаар утвал харавтар болдог, маш исгэлэн амттай нэгэн зүйл жимс); **хар будаа** у р г а м а л хар хальстай жижиг шар будаа, зэрлэг таримал хоёр зүйл байдаг); **хар өрөв** а м ь т а н (бие цагаан, омруу чандар харавгар өрөв); **хар овууна** а м ь т а н (ар жигүүр

бараан, улаан таш гэдэг шувуу): **хар гургуул** а м ь т а н (хэлбэр гургуултай адил бөгөөд бараан өнгөтэй шувуу); **хар галуу** а м ь т а н (бие хар, хушуу матаастай, хэрээнээс том нэгэн зүйл галуу); **хар хөхөө** а м ь т а н (толгой нуруу бараавтархан, сүүлэндээ цагаан чандартай, охор хөлтэй, тавгийн өмнө хойноо хошоод хуруутай нэгэн зүйл шувуу); **хар хэрээ** а м ь т а н (нэгэн зүйлийн бараан шувуу); **хар сойр** а м ь т а н (сойр шувууны нэгэн зүйл); **хар тогоруу** а м ь т а н (тогорууны нэгэн зүйл шувуу); **хар үнэг** а м ь т а н (цагаан сортой, хар үстэй үнэг); **хар хул** а м ь т а н (барс шиг бидэртэй, таван хумстай, өргөн цагаан нүүртэй нэгэн зүйл араатан амьтан, гавшгай бөгөөд догшин): **хар хулан** а м ь т а н (янз үнэгтэй адил болоод хар, үхрийн толгой шиг толгойтой, ганц эвэртэй, жил удвал хайрс ургадаг, сүрхий махчин араатан амьтан); **хар хайга** а м ь т а н (өргөн хавтгай хэлбэртэй нэг зүйл загас); **хар амар** а м ь т а н (амар загастай адил болоод хөх гэрэлтэй нэгэн зүйл загас, мах сайнгүй, зохимж муутай, сөсөөр нь нүдний өвчин засна); **хар голио** а м ь т а н (үнсэн өнгөтэй болоод харавтар, жигүүргүй, хэвэл том, түрс орхихгүй, хэвлээсээ хорхой гаргадаг голио); **хар дэлэнч** (нэгэн зүйл жижигхэн ялаа, төрөл зүйл олон); **хар ялаа** а м ь т а н (халдвар тараагч ялаа); **хар сайр, хар сарьс** (битүү туурайтны хондлойн арьсаар элдэж хийсэн илэг); 2. ш и л ж с э н муу санаа, хорт санаа, хорт муу үйл, сайн биш, аюул хөнөөлт, хүнд хүчир: **хар дотортой** (хар санаатай); **хар санаа** (сэжигтэй санаа, үл итгэх санаа, муу санаа); **хар үйл** (муу буруу үйл); **хар хэл ам** (ярвигтай маргаан тэмцээн); **хар дом** ш а ш и н (ямар нэгэн өвчнийг юухан хүүхнээр аргалж засах аргын зүйл); **арван хар нүгэл** ш а ш и н (арван цагаан буян гэдгийн нөгөө эсрэг үйл: биеэр үйлдэх 3, хэлээр үйлдэх 4, сэтгэлээр үйлдэх 3 болно); **хар хэлтэй** (а. ямагт муу, муухай, сэжиг хүрмээр үгтэй; б. зүхэлч): **хар үйл** (а. зүй зарчмаас гажуу буруу үйл ажил; б. бүдүүлэг үйл ажил); **хар санах** (сэжиглэх, итгэхгүй байх, муу санах); **хар буруу санах** (муу санаа санах); **хар гэр** (шорон); **хар салхи** (маш хүчтэй салхи); **хар шуурга** (аюулт хүчит шуурга): **хар дэлэн** (хонь ямааны сүү гарахгүй болох нэгэн зүйл халдварт өвчин, их төлөв дэлэн нь хавдаж сүү нь ширгэнэ); **хар цэцэг** (а. цагаан цэцэг өвчин буруугаар эрхэж хүндэрсэн нь; б. хонинд тохиолдох нэгэн зүйл өвчин); **хар хүч** (а. байдаг хүчээрээ; б. харгис түрэмгийгээр); **хар муйхар** (тэнэг бодлогоор); **хар ажилчин** (оюуны биш, биеийн хөдөлмөрийн хүмүүс); **хар ажил** (биеийн хөдөлмөрийн ажил); 3. ярших удсан, чирэгдэлтэй; *хар бороон дундуур; хар өглөөгүүр;* 4. ш и л ж с э н төрийн, шашны биш; **хар болох** (а. хир буртагтай болох, б. лам дүрмээ өөрчлөх); **хар хүн** (а. эр эм бололцогчдын эрий нь; *хар хүн нь малдаа явав; хар хүнийгээ ирэхэд хэлэв;* б. ердийн эр хүн лам биш; *төрийн хар хүн);* 5. ш и л ж с э н ганц, өөрийн, хувиа; **хар бие** (ганц бие; *хар биеэр зүтгэх; хар биеийн хөлс);* **хар толгойдоо гомдох** (өөрийнхөө биед гомдох); **хар амиа бодох** (зөвхөн амь хувиа бодох); ☆ **хар бага наснаас** (балчир бага наснаасаа); **хар ямаацах** (хүүхдийн наадам; хүүхэд ямаа чоно, эзэн хүн, хоточ нохой болон, хүн нохой нь чононоос ямаагаа хамгаалж наадна); **хар тэргүүт** (хамаг хүмүүс, хүн төрөлхтөн); **хар элэгтэй** (хамаатай биш): **хар буух** (харамсан гэмших, хайран юм гэж сэтгэл гутрах); **хар шал жинхэнэ** банзан шалны дорхи сургааг шал); **хар тавхай** (тавхайны ёроол); **хар дарах** (их л айж зүүдлэх); **хар сээр** (хүзүү сээрийн завсар дахь гаднаас түгдийж үзэгдэх нэг нугалам яс). ᠬᠠᠷ ᠭ

ХАР II хардах санаа, хэтэрхий муу санаа; *хар ихтэй;* **хар хор** (буєдын сайнд тачаадах найдангуй сэтгэл буюу хэтэрхий хартай сэтгэл). ᠬᠠᠷ ᠭ

ХАР III зарим үгтэй хавсран орж бас бус гэсэн утгаар хэлэгдэнэ; *данс хар; морь хар; хүн хар.* ᠬᠠᠷ ᠭ

ХАР IV: **хар хийх, хар няр хийх** хатуу юмны унах, хавирахад гарах чимээ; **хар хур хийх** (нохойн довтлон дайрах, хуцах аялга). ᠬᠠᠷ

ХАРАА I 1. нүдний харах чадал; *хараа сайтай; нүдний хараа муудах; хараа орох;* **хараа харалган** (нүд харсаар болович юм үл үзэх буюу үзэх нь зэхий муу); 2. бууны овоо онь; **овоо хараа, онь хараа** х о р ш.: *овоо хараагий нь таарууулах;* 3. дурангийн харах мөр; *зөрүү харааталй дуран;* 4. ш и л ж с э н анхаарал ажиг, хэтийн бодол; *хараандаа авах; алсын хараатай байх.* ᠬᠠᠷᠠᠭ ᠭ

ХАРАА II домбо сав зэргийн амсрын дэрэвгэр хэсэг; *домбоны хараа; хөхүүрийн хараа.*

ХАРАА III бичиг, данс; *бичиг хараа; данс хараа.* ᠬᠠᠷ ᠭ

ХАРАА IV харгаа. ᠬᠠᠷᠠᠭ ᠭ

ХАРАА V алс холыг харах асар хотон, таг; *хараа асар.*

ХАРАА VI харалдаа, ана мана; **хараа бараа, хараа харалдаа** х о р ш.; *тэр хоёр хараа бараа байна.*

ХАРААГДАХ хараахын үйлдэгдэх хэв.

ХАРААГҮЙ 1. нүдний хараа муу; **хараагүй болох** (сохор болох); 2. үзээгүй, үзсэнгүй; *би түүнийг хараагүй өнгөрч билээ.*

ХАРААЛ зүхэл, хараах үг, зан үйл; **хараал зүхэл** х о р ш.; *хараал тавих; хараал хийх; хараалын үгүүр цус, ерөөлийн үгүүр тос* х у у ч; **хараал идэх** (бусдад хараалгах); **хараал хүрэх** (бусдын хараасны адил муу тохиол болох).

ХАРААЛГАХ 1. хараахын үйлдүүлэх хэв; 2. хараагдах; *хүнд хараалгах.*

ХАРААЛАХ бараалах.

ХАРААЛЦАХ хараахын үйлдэлцэх хэв.

ХАРААЛЧ их хараадаг хүн, зүхэлч.

ХАРААМТГАЙ хараах зантай, хараамхай.

ХАРААМХАЙ хараамтгай.

ХАРААН холыг харах өндөр газар.

ХАРААТ харьяат, эрхшээлд байгаа, ямар нэгэн улсын мэдэлд орших; **хараат орон** (тусгаар тогтносон бүрэн эрхгүй, бусад улсын мэдэлд, бусдын эрхшээлд орших орон).

ХАРААТАЙ I 1. хараа бүхий; *хараатай газар;* 2. харсаар; хараатайгаа унтах; 3. бараатай; **хараатай бараатай** х о р ш..

ХАРААТАЙ II х у у ч и р с а н олон харьяат албат иргэнтэй.

ХАРААХ муухай болтугай гэж зүхэх; **хараах ерөөх, хараах зүхэх** х о р ш.; *харааж үл болно!*

ХАРААХАН 1. арайхан; *хараахан болоогүй; хараахан биш;* 2. сая, дөнгөж; *хараахан завдмагц; хараахан хүрмэгц.*

ХАРААЦАЙ бялзуухайн намын, хурдан нисдэг, хурц шовх далавчтай, жижиг шувууны ерөнхий нэр; *үхэр хараацай хонин хараацай; хараацайн үүр;* **алтан хараацай** а м ь т а н (хот суурин газарт үүрлэн орших нэгэн зүйл хараацай, хорт шавьж иддэг ашигтай шувуу); **тэмээн хараацай** а м ь т а н (биеийн урт нь 22 сантиметр орчим, өдний хэмжээ 25 сантиметр орчим урт, аливаа хортон шавьж иддэг ашигтай шувуу).

ХАРАВТАР баахан хар, нилээд хар.

ХАРАГДАХ харахын үйлдэгдэх хэв, үзэгдэх; *үзэгдэх харагдахын аргагүй түргэн; харагдах газар сууж байв.*

ХАРАГДУУЛАХ харагдахын үйлдүүлэх хэв.

ХАРАГЧ эм хар; *харагч гүү; харагч үнээ.*

ХАРАГЧИН I эмэгчин хар, эм хар; *харагчин гахай.*

ХАРАГЧИН II а м ь т а н сүүл нь урт, хөмсөг цайвар шар, том дуутай нэгэн зүйл бялзуухай; **харагчин хараацай** а м ь т а н (хушуу хар, толгой хүзүү хүрэн улаан, ар жигүүр хар болоод нарийн, цагаан чандартай, сүүлийн уг улбар болоод үзүүр нь шар нэгэн зүйл шувуу.

ХАРАЙЛ нэгэнт дэвхэрч зогссон газар; *нэг харайл газар; хоёр харайл газар.*

ХАРАЙЛАХ байн байн харайх.

ХАРАЙЛГАХ харайхын үйлдүүлэх хэв.

ХАРАЙЛТ харайх үйлийн нэр; *уртын харайлт, өндрийн харайлт; харайлтын өндөр.*

ХАРАЙЛУУЛАХ харайлахын үйлдүүлэх хэв.

ХАРАЙХ үсрэх, цовхрох, үсрэн дүүлэх, дэвхрэх: **гүйх харайх** х о р ш.; *горхин дээгүүр харайх; босон харайх; модон морь харайх.*

ХАРАЛГАН нүд өдөр үзэх байтлаа шөнө огт үл үзэх; хол ойрын хараа муутай **харалган сохор** (хүн амьтны нүдний хэлбэр асар хувирсангүй, уг хэвээр мэт атлаа үзэхгүй болсон).

ХАРАЛГАНДАХ хэтэрхий харалган болох.

ХАРАЛГАНТАХ харалган болох.

ХАРАЛДАА хавьцаа, ойролцоо чиг; *нас харалдаа; харалдаа хаалга; харалдаа уул.*

ХАРАЛЗАХ 1. байн байн харах, харгалзах; 2. ядуу зүдүүд бага сага юм өгөх.

ХАРАМ юмандаа нэн харуу, харамч; *харам сэтгэл; харам зан.*

ХАРАМЖ бусдын тусад зориулан хариу болгож өгөх юм; **харамж өгөх** (тусалсанд хариу баяр хийх).

ХАРАМЛАХ харам зан гаргах, юмандаа нэн шунах; *ялимгүй юмыг харамлаад өгсөнгүй; би чамд харамлах ч үгүй; харамлавал, хар нохойн хоол болно.*

ХАРАМЛУУЛАХ харамлахын үйлдүүлэх хэв.

ХАРАМНАХ харамлах.

ХАРАМЧ сүрхий харамлах зантай, харуу, харам; *харамч хүнд хань ховор* з үй р.

ХАРАНГА хүрэл мэтээр хийсэн, дүгрэг хэлбэртэй, цохиж дуу гаргах хөгжмийн зэвсэг; *хүрэл харанга ;харанга цохих.*

ХАРАНГАДАХ өлсч ундаасан үхэтгэн унах; *харангадан ойчих; ихэд цангаж харангадахад ойрхон явав.*

ХАРАНГАСААХ харангасахад хүрүүлэх, харангасуулах.

ХАРАНГАСАХ харангадах.

ХАРАНГАСУУЛАХ харангасахын үйлдүүлэх хэв, харангадуулах.

ХАРАНГУЙ I харанхуй.

ХАРАНГУЙ II харавтархан; *харангуй өнгө.*

ХАРАНГУЙДАХ харанхуйдах.

ХАРАНГУЙЛАХ харанхуйлах.

ХАРАНДАА бал голоор бичих, зурахад хэрэглэх голдоо балтай бичгийн хэрэглэл; *харандаагаар бичих; харандаа үзүүрлэх;* **будгийн харандаа** (өнгийн балтай харандаа); **хортой харандаа** (норгож бичвэл бэх мэт өнгө гарах тусгай балтай харандаа).

ХАРАНХУЙ 1. гэрэлгүй, гэгээн биш; *харанхуй шөнө; шөнийн харанхуй; үүрийн харанхуй; тасалгаа дотор чийдэн асаагүй, харанхуй байв; харанхуй нүх; харанхуй манан татах; хавар өнгөрвөл зун ирнэ, харанхуй арилбал гэгээн ирнэ* з үй р; **харанхуй мод** (үлэмж шигүүн ой); 2. ш и л ж с э н боловсролгүй, бүдүүлэг, мунхаг; *бүдүүлэг харанхуй хоцорсон ард түмэн сэргэн босов;* 3. битүүлэг, бүрхэг, тодорхойгүй; *харанхуй хэрэг; харанхуй будлиан.*

ХАРАНХУЙДАХ хэтэрхий харанхуй болох.

ХАРАНХУЙЛАХ харанхуй болох, харанхуй болгох; *тэнгэр бүрхэн харанхуйлах; гэрэл таглаж харанхуйлах.*

ХАРАНХУЙЛУУЛАХ харанхуйлахын үйлдүүлэх хэв.

ХАРАХ I 1. нүдээр үзэх; *харсаар байтал хаалга дээр хүрээд ирэв; ханилснаа шинж, харснаа лавла* з үй р; **өөдөө харах** (дээшээ харах); **зөрүү харах** (нүүрээ буруулан зайлуулж харах); **муухай харах, аягүй харах** (ер бишийн аягүй байдлаар хялайн ширвэж харах); **бараа харах** (алив юмны бараа үзэх үзэгдэх); **ойрыг харах** (өнөө маргаашийг бодох); **холыг харах** (алс хэтийг бодож болгоомжлох): **далим харах** (таширмыг бодох); **аянтал харах** (ташрам далимыг бодох); **морь харах, мөр харах, бараа харах** (бие засах); **сэтгэл харах** (хүний бодол санааг харалзан үзэх); **өө сэв харах** (бусдын гэм алдлыг сэм ажиг дарж байх); **нутаг харах, буурь харах** (оршин суух орон сав барих, байгуулах газар эрэх); **хүний царай харах** (бусдын эрхшээлд эрхгүй орж автагдах); **хүний гар харах** (бусдын эрхшээлд автагдан, эрхгүй дагах болох); **хүний ам харах** (өөрийн санаа бодолгүй, бусдын юу гэх амыг аядан дагах болох): **буруу харах** (а. ц э э р л э с э н үхэх; б. эндүүрч таних; в. зөв зүйтэй биш зан байдал гаргах; г. нүүрээ буруулах); **нүүр харах** (тал тохой татаж, ялгавартай үзэх); **тал харах** (танил, дотныгоо ялгаварлан үзэх); **нүүр тал харах** (дээр дор, сайн муугаар ялгаварлан үзэх); **мал харах** (мал хариулах, адуулах): **харах эрхтэн** (нүд); **2. дэмжих, асрах, тэтгэх;** *харж үзэх хүнгүй амьтан;* **хүүхэд харах** (хүүхдийг асарч хүмүүжүүлэх).

ХАРАХ II арьс шир зэргийн юмыг хусах, элэх; **хусах харах** х о р ш..

ХАРВАА I а м ь т а н гол мөрөнд төрдөг, маш жижигхэн болоод өргөн, хэлбэр хайгатай адил нэгэн зүйл загас.

ХАРВАА II 1. харваж онох чадвар; *харваа сайтай; харваа муутай;* 2. харалдаа, яг чиг; **харваа хатгаа** х о р ш.; *энэ хөтлөөр давмагц очих гэсэн айлдаа харваа хатгаа хүрнэ.*

ХАРВААЧ (ИН) I харваж чаддаг хүн; *сур харваач; шагаа харваачин.*

ХАРВААЧ II: **харваач өвс** у р г а м а л өндөр иштэй, нарийн навчтай, сундуутай хурц үзүүртэй нэгэн зүйл өвс, ширдэг хийхэд хэрэглэнэ.

ХАРВАГДАХ харвахын үйлдэгдэх хэв.

ХАРВАГЧ харвадаг; *харваач од;* **харваач өвс** (хялгана).

ХАРВАЛ сум харвах тусгал.

ХАРВАЛАХ зэрэг зэрэг харвах ,олонтоо харвах.

ХАРВАЛГА харвах үйлийн нэр.

ХАРВАЛТ харвах явц, харвах байдал.

ХАРВАЛЦАХ харвахын үйлдэлцэх хэв.

ХАРВАХ 1. нумын хөвчийн чадлаар сумыг үсэргэх, чавх буюу хуруугаар нясалж шагаа, харвуулын сумыг үсэргэх; *сур харвах; шагаа харвах;* 2. алив сум, пуужин, хиймэл дагуул тэргүүтнийг хөөргөх; *сум харвах; пуужин харвах; мина харвах; хиймэл дагуул харвах;* 3. шингэн зүйл олгойдон сацах; *тархинд цус харвах;* 4. од унах; *од харвах;* 5. нарны хэтэрхий илчинд дайрагдах, цохигдох; *нар харвах;* 6. зарим нэгэн юмыг юмаар шидэж үсэргэх, онох; *хушга харвах; бай харвах;* 7. зарим амьтны биеэ хурааж байгаад үсрэх; *мөгөй харвах;* 8. шилжсэн маш хурдан давхих; *хар гүйхээрээ харваж гарав; харвасан сум шиг түргэн одов;* 9. шилжсэн ухаан санааны түргэн түргэн орж ирэх; *ухаан харвах;* **сумаа харваад, нумаа нуух** (бусдыг далдуур хатган өдөөж ямар нэгэн үйл үйлдүүлээд, биеэ нууж үлдэх).

ХАРВИГНАХ 1. харвин суух, хэвэлд өөхтэй болох, таргалах; 2. шилжсэн харвин мэт хунирах, унжих; *дээлийн өнгө татаж дотор нь харвигнах.*

ХАРВИН хүний хэвлийн хүйснээс дооших газар, цоройны өөх, хэвлийн гадна талын өөх; **харвин суух** (гэдэслэх).

ХАРВИНТАХ харвин гарах, харвинтай болох, харвин суух.

ХАРВАР харавтар барс.

ХАРВИР амьтан талд оршдог эрээн жигүүртэй нэг зүйл шувуу.

ХАРВИС ихэс, амьтны умайн дотоод дахь үр зулзага тогтох сав.

ХАРВОР I сөл гэдэг өвс; *харвор өвс.*

ХАРВОР II ургамал янз бал модтой адил, навч зузаан болоод зөөлөн, гадар ногоон, дотор цайвархан, зулгарахгүй, үрийг таривал түргэн өсдөг нэг зүйл мод.

ХАРВУУЛ харвахад хэрэглэх годил; *харвуул годил; мина харвуул* (мина харвах зэвсэг, миномёт).

ХАРВУУЛАХ 1. харвахын үйлдүүлэх хэв; 2. харвагдах.

ХАРГАА уршиг; *цаг хожимдсоны харгаагаар эс явав; үл анзаарсны харгаа.*

ХАРГАЙ ургамал гачууртай адил болоод яс чийрэг, чанар хүнд, дурс зузаан, уул хөвчийн жихүүн газарт ургадаг нэг зүйл мод, хар мод ч гэдэг.

ХАРГАЛДАХ харгахын үйлдэлдэх хэв, харшилдах, маргалдах, тэмцэлдэх.

ХАРГАЛДУУЛАХ харгалдахын үйлдүүлэх хэв.

ХАРГАЛЗАГДАХ харгалзахын үйлдэгдэх хэв.

ХАРГАЛЗАГЧ харгалзах үүрэг гүйцэтгэгч хүн.

ХАРГАЛЗАХ 1. харах, хянах, сахих, манах; *манаж харгалзах;* 2. тэтгэх, харж үзэх; *харгалзан асрах;* 3. анхаарах, анхаарч үзэх; *онцгой байдлыг харгалзан үзэх; хөрөнгө чинээний байдлыг үл харгалзах; цаг үеийн байдлыг харгалзан.*

ХАРГАЛЗЛАГА харгалзах үйлийн нэр.

ХАРГАЛЗУУЛАХ 1. харгалзахын үйлдүүлэх хэв; 2. харгалзагдах.

ХАРГАМ морь малын олон яс нийлэхийн хойтох хэсэг газар мөн газрын арьс; ☆ **харгам хатгах** (хатгамлах).

ХАРГАМЛАХ торгомсог дэвсгэр дээр цэцэг оёх, хатгах.

ХАРГАНА ургамал ургамлын нэгэн төрлийн ерөнхий нэр, зүйл ялгал олон; *улаан харгана; алтан харгана; үхэр харгана; морин харгана; бор харгана; өргөст харгана.*

ХАРГАХ 1. харилцан дайралдах, тохиолдох; 2. харилцан маргах, тэмцэх.

ХАРГАЦАЛДАХ харгацахын үйлдэлцэх хэв, харилцан харгах.

ХАРГАЦАХ 1. харгах; 2 .эсрэг дайрах.

ХАРГИ усны түргэн урсгал; *голын харги.*

ХАРГИЛ I хашир, догь.

ХАРГИЛ II хариг.

ХАРГИЛ III ургамал навч алимын модны адил болоод дурс харавтар буюу улаавтархан нэгэн зүйл мод

ХАРГИС 1. шудрага биш, хэдэр муу зантай, догшин хэрцгий, ширүүн авиртай; *маш хар-*

гис хүн; харгис зан; 2. хувьсгалд ялагдан өмхөрч, мөхөж байгаа анги, эрх мэдэл, улс төрийн ноёрхлоо буцааж гартаа авахын тул хувьсгалт хөдөлгөөн, нийгмийн дэвшилт явдлыг ширүүн хэрцгийгээр дайран дарах бодлого-тон; *харгис зандалчин; харгис үзэлтэн.*

ХАРГИСАХ мал адгуусны ижил буюу үр зулзагаа өмгөөлөн харамсаж хамгаалах.

ХАРГИСЛАГДАХ харгислахын үйлдэгдэх хэв.

ХАРГИСЛАЛ харгислах үйлийн нэр; *харгислал нь хэтэрсэн хэрэг.*

ХАРГИСЛАХ харгис авирлах, дарлаж зовоох; *урьд ноёд түшмэд, ард түмнийг харгислан дарлаж байв.*

ХАРГИСЛУУЛАХ 1. харгислахын үйлдүүлэх хэв; 2. харгислагдах.

ХАРГУЙ өргөн тодорхой зам; **зам харгуй** х о р ш..

ХАРГУУЛАХ 1. харгахын үйлдүүлэх хэв; 2. нэгэн юмыг нөгөөд харьцуулан тэнцүүлэх; *өгөл авлыг харьцуулан суутгаж харгуулах; гавьяаг эндэгдэлд харьцуулан харгуулах.*

ХАРГҮЙ 1. номхон дөлгөөн, амарлингүй сэтгэлтэй; *харгүй номхон морь;* 2. хардах жөтөөрхөх, сэжиглэх санаа байхгүй.

ХАРД: дард хийх хатуухан юмны хавирах, унах мэтэд гарах чимээ сонсдох нь; *шүдээ хард хийтэл зуух.*

ХАРДАГДАХ хардахын үйлдэгдэх хэв, сэжиглэгдэх.

ХАРДАХ I 1. итгэхгүй, сэжиглэх, тааварлах; *хардаж сэжиглэх;* 2. жөтөөрхөх, бусадтай самуурав гэж бухимдах, уурлах; *хардаж уурлах.*

ХАРДАХ II хэтэрхий хар болох.

ХАРДУУЛАХ I 1. хардах I-ийн үйлдүүлэх хэв; 2. хардагдах.

ХАРДУУЛАХ II хардах II-ын үйлдүүлэх хэв.

ХАРЖИГ: харжиг харжиг хийх хар хар гэсэн чимээ сонсдох.

ХАРЖИГНАХ харжиг харжиг хийх чимээ сонсдох.

ХАРЖИГНУУЛАХ харжигнахын үйлдүүлэх хэв ,харжиг харжиг хийлгэх; *олон түлхүүр харжигнуулах.*

ХАРЗ хүчин хүйтэнд үл хөлдөх ус; *морио харзнаас услав;* ☆ **харз хэрэм** (хөрс цайгаагүй хэрэм).

ХАРЗАЙХ харзгар болох, хэрзийх.

ХАРЗГАР хэрзгэр; **харзгар хэрзгэр** х о р ш.;

ХАРЗДАХ хэтэрхий харз болох.

ХАРЗЛАХ харз гарах; *гол харзалжээ.*

ХАРИГ даргиа, таргил, урсгал усны ёроолын чулуу зэрэг дээгүүр таргилан урсах газар; *усны хариг.*

ХАРИГЛАХ хариг гарах, хариг тогтох.

ХАРИЛ харих үйлийн нэр, юмны буцах, буурах, харих нь.

ХАРИЛАХ харьд очих.

ХАРИЛТ буцалт, бууралт, харих нь.

ХАРИЛХАХ харь зан байдал гаргах, хүнийрхэх.

ХАРИЛЦАА (Н) харилцах нь; **харилцаа холбоо** х о р ш.; *соёлын харилцаа; дипломат харилцаа; харилцаагаа таслах; гадаад харилцааны талаар.*

ХАРИЛЦАН нааш цааш, бие биеийг; *харилцан бие биеийг хүндэтгэх; харилцан учрах; харилцан туслах; харилцан туслалцах, хамтран ажиллах гэрээ; харилцан хэлэлцэх; харилцан бие биедээ тус хүргэх.*

ХАРИЛЦАХ 1. нааш цааш, бие биендээ өгөх, шилжүүлэх; **захидал харилцах** (харилцан захидал бичилцэх); **дуу харилцах** (харилцан дуулах); **бөмбөг харилцах** (бөмбөгийг харилцан бие бие рүүгээ өгч наадах); 2. хамтран үйлдэх, бие биедээ нэвтрэлцэх; *биеэр харилцах; бичгээр харилцах; гадаадтай харилцах; утсаар харилцах; шуудангаар харилцах;* **харилцах данс** (банк, хадгаламжийн касснаас мөнгө авах, тэдгээрт өгч хадгалуулах данс).

ХАРИЛЦУУЛАХ харилцахын үйлдүүлэх хэв.

ХАРИЛЦУУР харилцах хэрэгсэл; *телефоны харилцуур.*

ХАРИМ махыг цавчиж амтлан жигнэх, хайрах зэргээр боловсруулсан идээ.

ХАРИМАЛ 1. нас өтөлж, тамир чадал буурсан нь; *харимал бөх;* 2. буцмал, эгмэл; **харимал буцмал** х о р ш.; *харимал эхнэр.*

ХАРИМГАЙ нум, хөвч мэтийн хүчтэй буцах юм; *харимгай нум.*

ХАРИН юмыг санаснаас ангид, сөрүүлэн өгүүлэхэд хэрэглэх холбоо үг; *харин ашгүй; харин иржээ; харин ойлгож мэдэв; адуу байна гэсэн, харин үхэр байв;* **харин ч** (чингэсний үрээр, чингэсэндээ, санаснаас; *харин ч хүн байсандаа болжээ; харин ч овоо юм байв).*

ХАРИУ I 1. асуусанд хэлэх үг, өгөх мэдээ; *хариу захидал; хариу үг; хариу хэлэх;* 2. юмны ор, хариулал, буцаж ирэх үр дүн; *аяганы хариу өдөртөө, агтны хариу жилдээ* з ү й р; *хариу бэлэг;* **хариу авах** (а. өшөө авах; б. асуусан лавласны шийдвэр авах); **хариу өгөх** (а. үг утгыг хариулах; б. өглөг хүргэлгийн ор өгөх); **хариу санах** (тусын хариу горилох); **хариу тэмдэг** (авсныг бичиж буцаах тэмдэг); **хариугаа авах** (өшөөг хариулах).

ХАРИУ II сариу, хэлтгий, хазгай, хөнтөргөн.

ХАРИУГҮЙ 1. асуусан хэлсний хариулалгүй; 2. өгсөн хүргэсэн юмны ор хариулалгүй; 3. хүчин чадвар маш дорой муу, өөдгүй; *миний бие хариугүй байна; хариугүй туранхай.*

ХАРИУЛАЛ хариулах үйлийн нэр, ач өшөөгийн хариу болгосон нь.

ХАРИУЛГА 1. хариулах үйлийн нэр; *хариулга сайтай;* 2. хариулт юм.

ХАРИУЛЛАГА хариулах нь, хариулалт.

ХАРИУЛАЛТ хариуллага.

ХАРИУЛАХ I хариу өгөх, хариулт өгөх; *өндөр дуугаар хариулах; ачийг бачаар хариулах; өшөөг хариулах.*

ХАРИУЛАХ II 1. харихын үйлдүүлэх хэв; 2. буцаах; *гэрт нь хариулах; нутагт нь хариулах; эрчий нь хариулах; мөнгө хариулах.*

ХАРИУЛАХ III 1. малыг билчээн харгалзан сахиж байх; *хонь хариулах; сүрэг хариулах;* 2. бусдын байдлыг хянаж ажиглах; *хүний нүд хариулах; багшийн нүдийг хариулж байгаад номыг нь авчихсан.*

ХАРИУЛТ хариулсан нь; *мөнгөний хариулт; хариултаа авсан.*

ХАРИУЛУУЛАХ хариулахын үйлдүүлэх хэв.

ХАРИУТАЙ 1. хариу бий; 2. хариу боддог; *хариутай бол бярууттай* з ү й р.

ХАРИУЦАХ I биедээ дааж авах, хүлээн авах, үүрэг болгож авах; *хариуцсан ажилдаа идэвхтэй; осолдвол би хариуцна; хожим хааш хэрэг болбол хариуцах эзэн байх ёстой.*

ХАРИУЦАХ II эсэргүүцэх, мөчөөрхөх, эсэргүүцэл тавих; *миний өмнөөс чи хариуцах хэрэггүй.*

ХАРИУЦАШГҮЙ хариуцаж боломгүй.

ХАРИУЦЛАГА 1. хариуцах үйлийн нэр, хариуцсан үүрэг, хариуцаж биедээ хүлээсэн нь, **үүрэг хариуцлага** х о р ш.; *эцэст нь хариуцлагыг хүлээх этгээд; хариуцлагыг дээшлүүлэх; хариуцлага ихтэй ажил;* 2. хууль зөрчсөн хэрэг; *эрүүгийн хариуцлагад татах.*

ХАРИУЦЛАГАГҮЙ хариуцлага муутай.

ХАРИУЦЛАГАТАЙ хариуцлага бүхий, хариуцлага сайтай; *хариуцлагатай нарийн бичгийн дарга.*

ХАРИУЦЛАГАТАН биедээ хариуцах үүрэг хүлээсэн ахлах албан тушаалтан; *хариуцлагатны зөвлөлгөөн.*

ХАРИУЦУУЛАХ хариуцахын үйлдүүлэх хэв.

ХАРИХ 1. гэр, нутагтаа буцах, эгэх; *үдэш харьж ирэв; нутагтаа харих;* 2. буцаж асгарах; *харьж асгарах;* 3. хатуу чанар сулрах; *төмрийн хат харих; зориг харих; эрч харих;* 4. дарагдах, буурах, багадах, намдах; *хаван харих; өвчин харих;* 5. буурах, доройтох, ядрах; *ид харих чадал харих;* **харих урвал** (химийн нэг зүйлийн урвал).

ХАРЛАГ хар алаг.

ХАРЛАХ 1. өнгө хар болох; *газар харлаж байна;* 2. ш и л ж сэ н муу байдалтай болох, үл өөдлөх; *бүр харалжээ! ээ, харал* ☆ **дотор харлах** (өрөн дээр аягүй болж эвэрлэх).

ХАРЛИГ харц, боол; ☆ **харлиг галуу а м ь т а н** (ар, жигүүр омруу цөм харвар өнгөтэй галуу); **харлиг хумхи** (гууль цутгахад хэрэглэх харавтар өнгөтэй хумхи).

ХАРЛУУЛАХ 1. харлахын үйлдүүлэх хэв; 2. харлагдах .

ХАРМАГ сондуул гэдэг **бутархаг** ургамлын үр, мойл мэт хэлбэртэй, **хүн иддэг; хармагт сондуул у р г а м а л** (нэгэн зүйл сондуул, үрийг хармаг, үндсийг гоюу гэнэ).

ХАРМАХ хамах, хамрах.

ХАРМИНЗАН улаан өнгөөр будсан одончуу.

ХАРНУДЭН а м ь т а н начин шувууны адил болоод бяцхан нэгэн зүйл махчин шувуу.

ХАРСАН: харсан тас а м ь т а н тасын нэг зүйл, усан тасаас биеэр бага, өнгө харавтар шувуу.

ХАРТАЙ 1. итгэхгүй, сэжигтэй, болгоомжтой; *хүний газар хартай явах хэрэгтэй гэдэг байжээ;* 2. хардамтгай, хар ихтэй; *хартай хүн.*

ХАРУУ I мөсөн дээгүүр явахад халтирахгүйн тулд асгасан шороон зам; **харуу асгах** (мөсөн дээгүүр зам болгож шороо асгах).

ХАРУУ II тарианы хөө, тарианы мөхлөг хөө болох буюу хатуурах өвчин; *улаан буудайн харуу; овёсны харуу.*

ХАРУУ III 1. харилцан харгалзан хамгаалахдаа чадмаг; 2. хайрлamтгай, харам сэтгэлтэй; *нойрт харуу.*

ХАРУУЛ I 1. манаа, манаж харгалзах этгээд; **харуул манаа** х о р ш.; *харуулд гарах; харуулын цэрэг; харуулын байр; харуулын цамхаг;* **харуул суулгах** (хязгаар боомтын газар сэргийлж харуул байгуулах); **харуул харах** (дайсныг сэрж сэргийлэх); 2. холын барааг харахаар байгуулсан өндөрлөг тагт.

ХАРУУЛ II модыг харуулдан засах багаж; **харуулын тархи** (харуулын төмөр, чих, шаантгаас бусад бүхэл бие); **харуулын төмөр** (харуулын ирт төмөр); **харуулын ул** (харуулын тархины доод этгээд, ир цухуйх хавтгай газар): **харуулын чих** (харуулын барих хөндлөн мод); **харуулын шаантаг** (харуулын төмрийг тогтоох шахуур).

ХАРУУЛАХ 1. харахын үйлдүүлэх хэв; 2. үзүүлэх, харгалзуулах.

ХАРУУЛДАХ I ирэх болов уу гэж горилон харж хүлээх; *чамайг өнөөдөр ирнэ гэж өдөржин харуулдав.*

ХАРУУЛДАХ II харуулаар өөлөх засах; *банз харуулдах.*

ХАРУУЛДАХ III түрүүлэг таварцаглан унах; *уруу газар харуулдаж унаад бэртэх шахав.*

ХАРУУЛДАХ IV бусдын хийж байгаа үйл ажлыг ажиглан тагнаж харах; *энэ хүн намайг ямагт харуулдаж байх болов.*

ХАРУУЛДУУЛАХ харуулдахын үйлдүүлэх хэв.

ХАРУУТАХ тарианы түрүү харуу өвчинд нэрвэгдэх; *тариа харуутах.*

ХАРХАН баахан хар, арай хар; *хархан нүдтэй.*

ХАРХИРАА а м ь т а н тогорууны төрлийн нэгэн зүйл шувуу, хар тогоруутай адил болоод үнсэн өнгөтэй, нисэхдээ дуу их.

ХАРЦ I нүдний харах байдал; *ширүүн харцтай хүн; зөөлөн харц.*

ХАРЦ II язгуур, угсаагүй, тайж биш; *харц ард; харц хүн.*

ХАРЦАГА I сээр ууц хоёрын хоорондох нуруу яс; *нэг нугалам харцага.*

ХАРЦАГА II харцгай.

ХАРЦГАЙ а м ь т а н богино махир хушуутай, урт хурц хумстай, махчин шувуу; *эр бор харцага маань, шигүүргэндээ хүчтэй* (ардын дуу).

ХАРЧГАР хорчгор, хоржгор, маш туранхай.

ХАРЧИГНАХ хатуу юмны хавиран харшилдаж сонсдох; *шүд нь харчигнан; тэрэг харчигнан хэрчигнэн явав.*

ХАРЧИГНУУЛАХ харчигнахын үйлдүүлэх хэв.

ХАРЧИЙХ харчгар болох, хэрзийх, хорчийх.

ХАРЧИН Өвөр монголын нэгэн аймаг.

ХАРЧИНДАХ тэмээн хөсөгт аянчны өглөө хоол идэж, малаа идэшлүүлээд ,бага үдийн хирд хөдлөн, шөнө дундын орчим хүртэл явах.

ХАРШ I орд; **орд харш** х о р ш..

ХАРШ II үл тохирох, үл нийцэх, эсрэг, эрс тэс, зохисгүй; *хуульд харш; биеийн эрүүл мэндэд харш. шинжлэх ухаанд харш.*

ХАРШААХ харших I II-ын үйлдүүлэх хэв.

ХАРШГҮЙ харш биш, харших зүйлгүй, харшлахгүй.

ХАРШИЛДАХ 1. харших I, II, III-ын үйлдэлдэх хэв ;2. ш и л ж с э н хоорондоо эв найзгүй болох, харгах, маргах; *харшилдан маргах.*

ХАРШИХ I 1. чулуу мэтийн хоорондоо цохилцох; *шаазан хоорондоо харших;* 2. ш и л ж с э н үл нийцэх, эс зохилдох; *хуульд харших;* 3. эрс гэс өнгө хольцолдон үзэхэд аятай болох; *өнгө харших.*

ХАРШИХ II хоол унд дутагдан тамир тэнхээ муудаж, турж эцэх, зүдэрч ядрах; *харшсан мал; ажилдаа харших.*

ХАРШИХ III хар санах, сэжиглэх, үл итгэх; *харшаад зааж эс өгөв.*

ХАРШИХ IV харын шинжтэй болох.

ХАРШЛАЛГҮЙ харшлах зүйлгүй.

ХАРШЛАЛДААН мөргөлдөөн тэмцэлдээн, харшлалдах нь.

ХАРШЛАЛДАХ байн байн харших, харилцан харш болох.

ХАРШЛАЛТАЙ харштай, үл нийцэх, үл зохицох, нийлэмжгүй, нийцэшгүй; *чингэхэд харшлалтай тал бий эсэх? нийтэд харшлалтай хэрэг.*

ХАРШЛАХ I харш болох, эс нийцэх, үл зохих; *харшлах шалтгаан байхгүй; уухад дотрт харшлахгүй унд.*

ХАРШЛАХ II бусдыг өө эрэлхийлэн хяхах, эсэргүүцэх.

ХАРШЛУУЛАХ харшлахын үйлдүүлэх хэв.

ХАРШМАЛ хар санаатай, муу санаатай; *харшмал хүн дээ.*

ХАРШТАЙ харшвал зохих зүйл бий; *хоорондоо харштай хоёр.*

ХАРШУУЛАХ I харших I-ийн үйлдүүлэх хэв.

ХАРШУУЛАХ II харшихын үйлдүүлэх хэв, харшаах; *морио хариуулах.*

ХАРЬ I өөрийн биш, гаднын, өөр, хүний; *харь газар үгээ бэхэл, халуун зуураа эвээ хичээ* з ү й р; **харь улс** (гадаад улс); **харь хэл** (өөрийн биш хэл); **харьд өгөх** (охиныг хүргэнд өгөх); **харийн хүн** (гадаад улсын буюу өөр аймаг захиргааны хүн).

ХАРЬ II усан дотроос юм утган шүүрдэж авах торон шүүр.

ХАРЬДАХ хариар утган шүүрдэж авах; *загас харьдах.*

ХАРЬДУУЛАХ харьдахын үйлдүүлэх хэв.

ХАРЬТ бугалаг чөмөг.

ХАРЬТАН гийчин, зочин.

ХАРЬЦАА (Н) 1. өөр өөр хэмжигдэхүүн, юм, үйл явдлыг жишсэн жишиг; *өндөр намын харьцаа; урт богиный харьцаа; хоёр хэмжигдэхүүний харьцаа;* 2. харилцаа; *олон улсын харьцаа; харьцаа сайжрах.*

ХАРЬЦАНГҮЙ харьцааны чанар; *харьцангуй өндөр харьцангуй чанар.*

ХАРЬЦАХ харилцах, харилцаатай болох, жиших.

ХАРЬЦУУЛАХ харьцахын үйлдүүлэх хэв; *харьцуулан үзэх.*

ХАРЬЯА (Н) захиргааны талаар буюу ямар нэгэн учраар хамаарагдах нь; *хөдөө аж ахуйн яамны харьяа байгууллага; танай харьяанд байгаа мал.*

ХАРЬЯАЛАГДАХ харьяалахын үйлдэгдэх хэв; *шууд харьяалагдах газар.*

ХАРЬЯАЛАХ харьяандаа авах, хамаарах; *харьяалж байгаа байгууллагын төлөвлөгөөний биелэлт сайжирчээ;* **харьяалахын тийн ялгал** (монгол хэлний хоёрдугаар тийн ялгал).

ХАРЬЯАЛУУЛАХ харьяалахын үйлдүүлэх хэв.

ХАРЬЯАТ 1. харьяа; **харьяат газар** (захиргааны талаар хамаарах газар); 2. харьяалагдах этгээд; *монголын харьяат; гадаадын харьяат;* 3. х у у ч и р с а н албат, захирагдагч; *харьяат ард.*

ХАС I хаш; **хас хатгуур цэцэг** у р г а м а л (өндөр иштэй, нарийн шүхэр бүхий цагаан цэцэгтэй, үнэр анхилмал ургамал): ☆ **хасын туулай** (сарны ёгт нэр).

ХАС II гуяны дотор талын дээд нийлэлт газар; **гуя хас** х о р ш..

ХАС III дөрвөн үзүүрий нь тэгш өнцгөөр нугалсан тоонолж хэлбэртэй зураг; *хас тэмдэг' хас тамга.*

ХАСАГ I тюрк хэлний бүлгийн хүмүүс, Монголын баруун аймгуудаар, Зөвлөлтийн Казахстан зэрэг газар оршино.

ХАСАГ II тулгын цагариг; *тулгын хасаг; дөрвөн хасагтай тулга;* ☆ **хасаг тэрэг** (мал хөллөж ачаа ачих том тэрэг).

ХАСАГДАХ хасахын үйлдэгдэх хэв.

ХАСАГДАХУУН 1. хасагдаж буй тоо; 2. хасахад өртөгдөх юм.

ХАСАЛГАНА у р г а м а л уулархаг газар ургадаг мөнх ногоон, бутархаг ургамал, цэцгийн өнгө шар болоод гоёмсог.

ХАСАЛТ хасах үйлийн нэр; *хасалт нь ихдэх.*

ХАСАЛЦАХ хасахын үйлдэлцэх хэв.

ХАСАРВААНЬ у р г а м а л халуун орны, амттай жимстэй, нүхэрхэг навчтай мод мөн жимс.

ХАСАХ 1. хорогдуулах, хороох, хэмжээг бага болгох, багатгах; *өндрөөс нь хасах; хасч хаях;* **эрхийг хасах** (хүний эрхийн заримыг хязгаарлах; *сонгуулийн эрхийг хасах);* 2. цөөтгөх, цөөн болгох; *олон зургаас заримыг хасах; хугацаандаа ирээгүй хүнийг хасах хэрэгтэй;* 3 .тоо бодлогын үйлдэл, хоёр тоогоор гуравдугаар тоог гаргах бөгөөд гуравдугаар нь хоёрдугаар тоотой нийлэхдээ нэгдүгээр тоо болно; *арваас дөрвийг хасахад зургаа болно;* **хасах тэмдэг** (хасах үйлдлийг заах тэмдэг).

ХАСДАА з у р х а й Буд гаргийн харъяат нэгэн од, өмнө зүгт оршино.

ХАСЛАГА хасалт хасах нь.

ХАСМАЛ хагасыг хасч авсан, заримыг хассан нь; *хасмал юм.*

ХАСУУЛАХ 1. хасахын үйлдүүлэх хэв; 2. хасагдах.

ХАСУУР төмөр дархлахад хэрэглэх, хасч таслах багаж.

ХАТ I төмөр, болдын хатуу, хатан чанар; *хат сайтай хутга; хат нь тохирох;* **хат нь гарах** хатан чанаргүй болох).

ХАТ II голох, чамлах, санасанд хүрсэнгүйд гаргах аялга, *дуулахаа хат; хийхээ хат; идэхээ хат.*

ХАТААГДАХ хатаахын үйлдэгдэх хэв.

ХАТААЛГА хатаах үйлийн нэр; *ноосны хатаалга.*

ХАТААЛГАХ хатаахын үйлдүүлэх хэв, хатаахад хүргүүлэх.

ХАТААЛЗАЙ I у р г а м а л ойт хээрийн бүсэд ургадаг, олон наст, богино ургамал, навч өтгөвтөр, үстэй, мал төдий л иддэггүй.

ХАТААЛЗАЙ II хатанхай болсон нь; *хатаалзай амьтан.*

ХАТААЛТ I хатаах үйлийн нэр, хатаасан чанар.

ХАТААЛТ II төмөр эдлэлийг ихэд халааж гэнт хөргөж хатан чанартай болгохы нь.

ХАТААМАЛ 1. хатаасан нь; 2. зүсч хатаасан талх.

ХАТААХ I 1. хатах I-ийн үйлдүүлэх хэв; *угаасан юмыг салхинд тавьж хатаах; хатаасан загас;* 2. ш и л ж с э н цангаах; *ус уулгалгүй хатааж алах нь!* 3. зовоох, үйлий нь үзэх; 4. ш и л ж с э н тураах ,эцээх.

ХАТААХ II хатах II-ын үйлдүүлэх хэв; *төмөр хатаах.*

ХАТАВЧ 1. монгол гэрийн хаалга хана хоёрын уулзвар газар; *хатавчаар их хүйтэн орж байна;* 2. хаалганы далбаа; **хаалга хатавч** х о р ш..

ХАТАГТАЙ эмэгтэй хүний хүндэтгэл.

ХАТАЙР 1. хүн малын бие доройтож туранхилах өвчин; 2. тариалан ба өвс ургамлын үр боловсорч чадахгүй ялзран харласан буюу хавчиг дутуу болсны нь; ☆ **хатайрын цэцэг** у р г а м а л (буурцгийн аймгийн ургамал, хагас бут буюу хаяа жинхэнэ бут, нэг буюу олон наст, хос биш навчит, маш олон янз бий).

ХАТАЙРТАХ хатайр өвчин тохиох.

ХАТАЙРШИХ хатайр шинжтэй болох.

ХАТАМЖИХ хатуужих, тэсвэртэй байх, хатамжлах.

ХАТАМЖЛАХ хатуужин чармайж тэсвэрлэх, хатамжих.

ХАТАН I болд, төмөр зэргийн уян зөөлөнгүй, догшин хатуу; *хатан төмөр; уян хатан; уян хатны нь тааруулах.*

ХАТАН II ааг, амт маш сүрхий; **хатан амт** (амсахад тачаадам хүчтэй, аагтай, хахуун амт); **хатан архи** (маш хахуун архи); **хатан үнэр** (хатуу сүрхий үнэр).

ХАТАН III зан сэтгэл чанга, ширүүн; **хатан догшин** х о р ш.; *хатан сэтгэлтэй.*

ХАТАН IV 1. ноён хүний эхнэр; 2. эмэгтэй хүний хүндэтгэл; **хатан тоть** (бяцхан тотийн эмэгчин); ☆ **хатан хараа** а м ь т а н (толгой хүзүүгээрээ ихээхэн хар чандартай, хэрэлдэмхий зантай нэгэн зүйл шувуу); **хатан хараацай** а м ь т а н (хараацайгаас бяцхан бөгөөд цох бараан нэг зүйл шувуу); **хатан чацаргана** у р г а м а л (иш навч мартах өвстэй адил, долоо найман хэлтэс цэцэгтэй нэгэн зүйл ургамал, буга маш дуртай иддэг); **хатан сүйх** (нэгэн зүйл хээ угалз).

ХАТАНГА I хатан I.

ХАТАНГА II хатаалзай.

ХАТАНГАТГАХ тулган тушаах, тулган даатгах; *хатангатган захив.*

ХАТАНГИР 1. чийг, шим муу, хатсан нь; *хатангир газар;* 2. тарга хүч муу, туранхай, хатанхай; *хатангир амьтан;* **хатангир эрхтэн** (бие махбодын тэнхрэл доройтон, ажиллагаагүй болсон эрхтэн).

ХАТАНГИРАХ хатангир болох.

ХАТАНГИРДАХ хэтэрхий хатангир болох.

ХАТАНГИРТАХ хатангир байдалтай болох; *хатангиртсан хуруу.*

ХАТАНГИРУУЛАХ хатангирахын үйлдүүлэх хэв.

ХАТАНГИРШИХ хатангир шинжтэй болох.

ХАТАНДАХ хэтэрхий хатан болох.

ХАТАНДУУЛАХ хатандахын үйлдүүлэх хэв.

ХАТАНХАЙРАЛ бие махбодын тэжээл тэнхрэл доройтон, аль нэг эрхтний хатангир бага болох өвчин.

ХАТАНХАЙРАХ хатангир болох.

ХАТАНХАЙРУУЛАХ хатанхайрахын үйлдүүлэх хэв.

ХАТАХ I 1. хуурай болох, ус чийггүй болох; *нойтон өвс хатах;* **ам хатах** (аман дотор чийг шөлс бага мэт, аргуун болох); **хатсан газар** (хур бороогүй гандсан газар); 2. турж эцэх, өвчинд нэрвэгдэх; *өвчинд хатах;* 3. ш и л ж с э н цангах; *ам цангаж хатаж үхэхэд хүрэв!* 4. ш и л ж с э н ямар нэгэн юм үгүйлэгдэн мөрөөдөх, дутагдах; *гэрээ санаж хатаж байв.*

ХАТАХ II төмрийн зүйл хатан, хатуу болох.

ХАТГАА I хатгалга.

ХАТГАА II зэрэгцээ, зэрэг; *хар хээр хоёр морь уралдаад харваа хатгаа орж ирэв.*

ХАТГААС хатгасан нь, хатгалга.

ХАТГАГДАХ хатгахын үйлдэгдэх хэв.

ХАТГАГЧ 1. хатгадаг; *могой бол хатгагч амьтан; шивээ бол хатгагч өвс;* 2. өдөөгч; *өдөөн хатгагч;* 3. хатгагч уран, хатгамалч; *уран хатгагч*

ХАТГАЛАХ байн байн хатгах.

ХАТГАЛГА 1. хатгах үйлийн нэр; 2. **цээжээр** хатгаж өвдөх халуунтай өвчин: **цусан хатгалга** (уушиг үрэвсэх халуун өвчин); 3. ш и л ж с э н өдөөлөг, хатгаа; **өдөөлөг хатгалга** х о р ш..

ХАТГАЛДААН байлдаан.

ХАТГАЛДАХ хатгахын үйлдүүлэх хэв.

ХАТГАМАЛ хатгаж хийсэн юм; *хатгамал хөрөг; хатгамал цэцэг.*

ХАТГАМАЛЛАХ хатгамал оёх.

ХАТГАМАЛТ хатгамал хээтэй; *хатгамалт хөшиг.*

ХАТГАМАЛЧ хатгаж оёдог хүн; *уран хатгамалч.*

ХАТГАМЛАХ хатган оёх.

ХАТГАМЛУУЛАХ хатгамлахын үйлдүүлэх хэв.

ХАТГАС уд модны хөх арьс.

ХАТГАХ 1. үзүүртэй юмаар чичих, шаах; *шөвгөөр хатгах; өргөс хатгах; хуруугаар хатгах;* 2. могой, зөгий зэрэг хорхой шавьжийн хушуугаар хазах; *зөгий хатгах; могой хатгах;* 3. бие эрхтэн юмаар чичих мэт гэнт хүчтэй өвдөх; *өвдгөөр хатгах; хавиргаар хатгах;* 4. хатгамал оёх, утсаар угалз хээ гаргаж урлан оёх; *угалз хатгах; утас хатгасан хавтага;* 5. ш и л ж с э н өдөөн үймүүлэх; *хатган үймүүлэх; өдөөн хатгах;* 6. шигтгэж тогтоох; *хүж хатгах; туг хатгах;* 7. мөргөн тулж унах; *толгойгоороо газар хатгаж унах;* 8. багтаж зэрэгцэх; *хаяа хатгаж суух; хамар хатгаж идэх;* 9. оодрох; *эз нь хатгах; хоол нь хатгах.*

ХАТГИН Монголчуудын нэгэн овгийн нэр; *хатгин овгийн хүн.*

ХАТГУУЛАХ 1. хатгахын үйлдүүлэх хэв; 2. хатгагдах.

ХАТГУУР 1. юмыг хатгаж тогтоох суурь; *хүжний хатгуур; лааны хатгуур;* 2. хатгах зэвсэг, хануур; *хатгуур хутга;* 3. эмэгтэйчүүдийн толгойдоо зүүх чимэг; *үсний хатгуур; хатгуур зүү;* ☆ **хатгуур гэр** (овоохой буюу цээжин гэр); **хатгуур цэцэг** (хас хатгуур цэцэг).

ХАТГУУРЛАХ толгойд хатгуур чимэг зүүх.

ХАТИАР хатайр.

ХАТИАРТАХ хатайртах.

ХАТИГ арьс нимгэн газар идээрлэн үрэвсэх өвчин; *хатиг гарах; хатиг үрэвсэх;* ☆ **үмхий хатиг** (хоолойн дотор гарсан хатиг).

ХАТИГТАХ хатиг гарах.

ХАТИР моринь урьд нэг, хойт нэг хөлийг нэгэн зэрэг газар гишгэлэн явах явдал; *задгай хатир; хатираар явах;* **хатиртай морь; удган хатир** (гурван хөл нэгэн зэрэг газар гишгэн нэгэн зэрэг газраас хөндийрөн тавих явдал).

ХАТИРАХ 1. хатираар явах; *хатирч яваад жороолдог морь;* 2. бүжиглэн наадах нь.

ХАТИРУУЛАХ хатирахын үйлдүүлэх хэв.

ХАТИРЧ хатирдаг; *хатирч морь.*

ХАТМАЛ хатсан юм; *хатмал өвс; хатмал бяслаг.*

ХАТУУ 1. зөөлөн гэдгийн эсрэг утга; **хатуу хүтүү, хатуу хэтүү** х о р ш.; *чулуу мэт хатуу; хатуу ултай гутал; модот газар муу үг, хадат газар хатуу үг* з ү й р; ☆ **хатуу ус** (цэнгэг сайхан байтлаа зохимж муутай ус); **хатуу чихтэй, чих хатуу** (сонсголон муутай, дүлий); **хатуугийн тэмдэг** (цагаан толгойн «ъ» үсгийн нэр); 2. уян биш, зөөлөн биш, хөшүүн, хатан: **хатуу нум** (татаж тэлэхэд хялбар үл дийлэгдэх нум); **хатуу амтай морь** (амыг татахад авд үл дийлэгдэх морь); 3. хахуун, гашуун, чанга амттай; *хатуу архи;* **хатуу эм** (хор ихтэй эм); **хатуу хөрөнгө** (исгэх хөрөнгө); 4. чанга, шийдэмгий, шулуун, шудрага, бат; *хатуу хүн; хатуу эр; хатуу зориг;* 5. үл нугарах, нигүүлсэнгүй зөөлөн биш; **хатуу амтай** (ширүүн үгтэй); **хатуу сэтгэл, хатуу дотор** (энэрэлгүй сэтгэл); **хатуу зориг, хатуу санаа** (буцалтгүй, чанга тэсвэртэй зориг); **хатуу гар** (а. харамч, нарийн; б. хайр гамгүй; в. хэцүү бэрх); **хатуу шийтгэл** (хүнд шийтгэл); 6. ш и л ж с э н алт, мөнгө мэтийн үнэ бүхий хөрөнгийн зүйл; **хатуу хэтүү юм** (алт мөнгө тэргүүтэн).

ХАТУУВТАР баахан хатуу, хатуушиг.

ХАТУУДАХ 1. хэтэрхий хатуу болох; *хатуудаад хуурайгаар үрж эс чадав;* 2. хэтэрхий ширүүн, хэрцгий болох; *шийтгэл хатуудах.*

ХАТУУДУУЛАХ хатуудахын үйлдүүлэх хэв.

ХАТУУЖИЛ тэсвэр, хатуужих нь; **хатуужил хийх** (өнө удаан хатуужих, тэсвэрлэх).

ХАТУУЖИЛГҮЙ зориг тэсвэргүй.

ХАТУУЖИЛТАЙ зориг тэсвэр сайтай.

ХАТУУЖИХ тэсвэртэй болох, дааж давж чадах чадвартай болох, тэсвэрлэх; *зовлонг хатуужин давах.*

ХАТУУЖУУЛАХ хатуужихын үйлдүүлэх хэв.

ХАТУУЛАХ ширүүлэх, чангалах; *зоргоор нь тавихгүйн тул нилээд хатуулж үзэв.*

ХАТУУЛУУЛАХ 1. хатуулахын үйлдүүлэх хэв; 2. хатуулагдах.

ХАТУУРАХ хатуу болох, чангарах.

ХАТУУРУУЛАХ хатуурахын үйлдүүлэх хэв, хатуу болгох .

ХАТУУРХАГ хатуурхуу.

ХАТУУРХАХ 1. хатуу зан гаргах; 2. бэрхшээх.

ХАТУУРХУУ баахан хатуу, хатуу байдалтай, хатуушиг хатуурхаг.

ХАТУУРХУУЛАХ хатуурхахын үйлдүүлэх хэв.

ХАТУУХАН баахан хатуу.

ХАТУУШИГ хатуувтар.

ХАТУУШУУ нилээд хатуухан.

ХАХААС загас агнах дэгээний үзүүр.

ХАХААХ хахахын үйлдүүлэх хэв, хахахад хүрүүлэх.

ХАХАХ 1. залгисан юм хоолой руу нэвтрэн орохгүй тээглэн бөглөхөд сандран огзом огзом огих; *хуурай гурилд хахах; махыг том үмхвэл хахаж болно;* 2. ш и л ж с э н олноор чихэлдэн зорчих; *зах дээр амьтан хахалдаж чихэлдээд явж болохгүй шахам байна.*

ХАХАЛДАХ чихэлдэх, чихцэх.

ХАХИЛИГ а м ь т а н ой хаданд орших ятууны төрлийн шувуу.

ХАХИНАЛДАХ хахинахын үйлдэлдэх хэв, үймэлдэн сэлгүүцэн бужигнах.

ХАХИНАХ I тослоогүй юм хоорондоо хавиран чихэрч дуугарах; *тэрэг хахинах.*

ХАХИНАХ II хөлсөн үймцэх; *битгий хахинаад бай, ажилд садаа болно.*

ХАХИНУУЛАХ хахинахын үйлдүүлэх хэв.

ХАХИР 1. хатуу, хатан, ширүүн; **хахир газар** (хад чулуутай, хатуу ширүүн хөрстэй газар): 2. чанга, хатуу, цуурайтай; **хахир чанга, хахир хатуу** х о р ш.; *хахир дуутай.*

ХАХИРАХ хоолойгоо чаргагдуулан гадагш үлээх; *хахирч цэр гаргах;* **цусаар хахирах** (цустай цэр гарах).

ХАХИРДАХ хэтэрхий хахир болох.

ХАХИРУУЛАХ хахирахын үйлдүүлэх хэв.

ХАХИРШИХ хахирын шинжтэй болох.

ХАХИХ цагаан бурхан, улаануд зэргийн туурсан ярны хатаж хогжрон эхлэх.

ХАХРААХ хахрахын үйлдүүлэх хэв.

ХАХРАХ айраг мэтийн исгэлэн идээ хэтэрхий хүчтэй амттай болох; *хахарсан айраг.*

ХАХРУУЛАХ хахрахын үйлдүүлэх хэв, хахрахад хүргүүлэх.

ХАХУУЛ дөрвөн хуруу хир нарийн модны үзүүрт шуумгай төмөр хадаж, хулсны навчаар бүрж, тусгай тогтоон, усанд хаяж загас барих зэвсэг; ☆ **хахуул хаалга** (зах зээлийн газарт хүмүүсийн орж гарахад зориулан хийсэн хаалга).

ХАХУУЛАХ хахахын үйлдүүлэх хэв.

ХАХУУЛДАХ 1. загас барихаар хахуул тавих; 2. хахуулилах, хахууль өгөх; 3. тээглэх; *данхны цоргонд юм хахуулдаад гарахгүй болов.*

ХАХУУЛДУУЛАХ 1. хахуулдахын үйлдүүлэх хэв; 2. хахуулдагдах.

ХАХУЛИЛАХ хахууль өгөх.

ХАХУУЛЬ I өөрийн зүй бус хэргийг биелүүлэх, бүтээхийн тул албан тушаалтанд ил далд аргадан өгөх мөнгө буюу эд юм; хээл хахууль х о р ш.; *хахууль өгөх; хахууль идэхдээ дуртай түшмэл байжээ.*

ХАХУУЛЬ II арьсаар хийсэн бөмбөгний амсрыг халхлан тавих арьс; *бөмбөгний хахууль.*

ХАХУУЛЬ III нүхэн дахь ан амьтны утахад, галд түлэгдэхээс хамгаалан, галын цаад талд халхлан тавьж хагас хаасан хаалт; *утуурын хахууль; нүхний хахууль.*

ХАХУУЛЬДАХ хахууль өгөх, хахууль тавих.

ХАХУУЛЬЧ хахууль өгөх, авахдаа дуртай.

ХАХУУН I. амтны хатан, хошуун, нясуун; *хахуун амт; хахуун айраг;* 2. химийн идэж сүйтгэх бодис юм; *хахуун натри; хахуун будаг; хахуун шүлт.*

ХАХУН хахуун.

ХАЦАВЧ хатавч.

ХАЦАР 1. нүүрийн хоёр хажуу хэсэг; *улаан хацартай хүүхдүүд гудамжаар шуугилдан гүйлдэнэ;* **гэрээ хацар** (хацрын товгор хэсэг); 2. юмны хоёр хажуугийн хавтгай хэсэг; **хацрын төмөр** (хазаарын хэрэгсэл); **хуйны хацар** (бууны хуйн хоёр хажууд хийсэн төмөр); 3. юмны хавтас; *дэвтрийн хацар;* 4. хаалганы гуя модны дотуур янзлан хийсэн мод; *хацар мод нь салчжээ.*

ХАЦАРЛАХ 1. юманд хацар хийх; 2. голын ус хоёр захаараа хөлдөх; *гол хацарлах.*

ХАЦАХ хявцах, боож хяхах.

ХАЧ I бусдын гэм бурууг ухчлан, уудлан, ховлон хэлэлцэх үг; **хов хач** х о р ш..

ХАЧ II: **хач гүргэм** у р г а м а л **халуун** оронд ургадаг, гүргэмтэй адил маягийн будагт ургамал, эмнэлэг, хүнсний зүйлд чухал хэрэглэгддэг.

ХАЧИГ а м ь т а н үет хөлт жижигхэн шавьж, хонь малын биед оршиж цусаар амьдарна; **хачиг хувалз** х о р ш.: **хачиг шиг наалдах** (аг тэврэн наалдах).

ХАЧИГТАХ хачигтай болох.

ХАЧИН жигтэй, сонин, гайхмаар, этгээд; **сонин хачин** х о р ш.; *хачин янзын эд; ямар хачин хэрэг вэ?*

ХАЧИР I 1. махан хоолонд ногоо зэрэг юмаар хийсэн дайвар нэмэлт; *шарсан махны хачир;* 2. эм зэрэг юмны дээр дайж нэмсэн юм; *эмний хачир.*

ХАЧИР II тас шувуу.

ХАЧИРЛАХ хачир I-ийг дайж нэмэх.

ХАЧИРХАХ хачин байдал гаргах, түүнд сонирхон бахархах, сэвүүрхэх.

ХАЧИРХУУЛАХ хачирхахын үйлдүүлэх хэв.

ХАЧИХ хацах, хяхах, хясах.

ХАЧЛАГДАХ хачлахын үйлдэгдэх хэв, шүүмжлэгдэх.

ХАЧЛАХ бусдын муу бурууг гаргаж мэдүүлэх, ховлох; **ховлох хачлах** х о р ш.; *хачлан мэдүүлэх; хачлан заалдах.*

ХАЧЛУУЛАХ 1. хачлахын үйлдүүлэх хэв; 2. хачлагдах.

ХАЧРААГҮЙ хэлэмгий, чадамгай, гарамгай байдалтай; *хачраагүй хүн.*

ХАШ эрдэнийн чулуу, өнгө янз бүр, гоёл чимгийн зүйлд хэрэглэнэ; *хаш соруул; хаш аяга.*

ХАШАА 1. юмыг хүрээлэн хорих, халхлахаар тойруулж барьсан зүйл; *өвсний хашаа; малын хашаа; хашаа саравч олныг байгуулах;* **хашаа барих** (хашаа хороо босгож байгуулах); **хашаа хатгах** (сургааг модоор нэг-үзүүрийг газарт суулгаж хашаа барих); 2. хот, суурин газарт сургааг зэргийг хүрээлүүлэн барьсан хороо сууц; *амины хашаа; албаны хашаа; агуулах хашаа; хашааны дэвтэр; хашааны дугаар; хамар хашаа.*

ХАШААЛАХ 1. юмыг тойруулан хашаа барих; 2. хороолон хорих.

ХАШААЛУУЛАХ хашаалахын үйлдүүлэх хэв.

ХАШААС хашлага.

ХАШГАРАА хашгардаг зантай, хашгачаа гэдэг; *хашгараа хүн; онгироо хашгараа амьтан.*

ХАШГАРААН хашгаралдаан.

ХАШГАРАЛДААН бархиралдаан, зэрэг зэрэг хашгаралдах дуу.

ХАШГАРАЛДАХ хашгарахын үйлдэлдэх хэв.

ХАШГАРАЛЦАХ хашгарахын үйлдэлцэх хэв.

ХАШГАРАМТГАЙ хашгарах зантай.

ХАШГАРАХ өндөр дуугаар орилох, бархирах; *урай хашгарах; хашгарах дуу сонсдов; хашгаран дайрав.*

ХАШГАРУУЛАХ хашгарахын үйлдүүлэх хэв.

ХАШГАРЦГААХ хашгарахын олноороо үйлдэх.

ХАШГИЧАА хашгараа.

ХАШГИЧИХ байн байн хашгарах.

ХАШИВТАР нилээд хашин.

ХАШИГ хүний төрөл буюу дотно найртайн учир өмгөөлөн хамгаалах нь.

ХАШИГДАХ 1. хашихын үйлдэгдэх хэв; 2. боогдох, хаагдах, хоригдох; *усанд хашигдах; торонд хашигдах.*

ХАШИГНАХ 1. унах эдлэхэд явахгүй хойргоших, удаан хөдлөх; *морь хашигнаад байна;* 2. хүний хойрго, залхуу зан байдал гаргах; *хашигнаад ажил хийж өгөхгүй байна.*

ХАШИГНУУЛАХ хашигнахын үйлдүүлэх хэв.

ХАШИЛЦАХ хашихын үйлдэлцэх хэв.

ХАШИН I 1. малын оёг, удаан; *хашин морь; хашин моринд газар хол;* 2. залхуу, хойрго; **хашин хойрго** х о р ш.; **хашин моходог** (хойргошуу).

ХАШИН II хувцасны зүйлийн хуучирч муудсан, элэнгэ; *хашин гутал; хашин ул.*

ХАШИН III олон удаа боов боорцог чанаж бүцалгасан хуучин тос; *хашин тос.*

ХАШИН IV цайны шаар.

ХАШИНДАХ хэтэрхий хашин болох.

ХАШИР догь, нягт нямбай, эрэгцүүлэн хянагч; *хашир хүн; хал үзэж хашир таних нь амьдралд тустай;* **хашир суух** (хашир болох).

ХАШИРГҮЙ 1. хашир догь биш; 2. башир бачгүй, үнэнч.

ХАШИРДАХ хэтэрхий хашир болох.

ХАШИРЛАХ хашир зан гаргах, болгоомжлох; *хаширлаад жинхэнэ цагий нь болгож очив; хаширлаад хаширлаад оносонгүй.*

ХАШИРЛУУЛАХ хаширлахын үйлдүүлэх хэв.

ХАШИРТАЙ 1. ярвигтай, түвэгтэй, залхуутай; *хаширтай явдал;* 2. баширтай, бачтай.

ХАШИХ 1. юмыг тойруулан хүрээлж халхлах; *худаг хаших; өвс хаших;* 2. хашаанд оруулж хорих; *хурга хаших;* 3. тал бүрээс

хоргоон хорьж тогтоох; *сул морийг олон хүн хашиж байгаад барьж авав;* 4. ш и л ж с э н шахах, хавчих; *хашиж хавчих.*

ХАШЛАГ I у р г а м а л хуруугы хир том, амт баахан гашуувтар нэгэн зүйл жимс, идэж болно.

ХАШЛАГ II хашлага, хашаас; *худгийн хашлаг.*

ХАШЛАГА 1. юмыг хааж хорих, хаших хориул, хориг, хашаас, хашлага; *худгийн хашлага; тэрэгний хашлага; хашлагатай ор; тулганы хашлага хашлага далан* (голын захаар тулгаж хийсэн далан); 2. шагаа харвахад, сумыг тавьж няслах хэрэгсэл; *хашлага сум.*

ХАШРААХ хашрахад хүрүүлэх, хашруулах

ХАШРАЛ хашрах үйлийн нэр, залхал; *хашрал үзүүлэх.*

ХАШРАЛТАЙ хашравал зохилтой.

ХАШРАМЖ хаширч валхсан, залхамж.

ХАШРАХ залхах, дахин халдан үйлдэж чадашгүй болох; **хашрах залхах** х о р ш.; *хашир хүн гэж, хаширсан хүнийг хэлдэг* з ү й р; *би хаширсан, дахиад ер ингэхгүй.*

ХАШУУЛАХ 1. хашихын үйлдүүлэх хэв; 2. хашигдах.

ХАЮУЛАХ хаяхын үйлдүүлэх хэв; *хог хаюулах.*

ХАЮУР усан онгоцны сэлүүр.

ХАЮУРДАХ онгоцыг хаюураар сэлж явуулах.

ХАЯА юмны зах, хөвөө, хязгаар; **гэрийн хаяа** (гэрийн хана, туурганы ёроол тал); **хаяа манах** (гэрийн хаяаг шороогоор дарах): **хаяа сөхөх** (гэрийн туурганы хормойг дээш нь шуух); **хаяа буулгах** (сөхсөн хаяаг доош болгох); **модны хаяа** (модны зах); **уулын хаяа** (уулын тулах ёроол); **хаяагаа манах** (урьдаас болгоомжлон сэргийлэх); **хаяанд** (айл зэргэлдээ, дэргэд, маш ойрхон; *морь хаяанд байна; хүүхэд хаяанд сууж харагдана*); **тэнгэрийн хаяа** (тэнгэр газар хоёрын буюу их ус тэнгэр хоёрын нүдэнд харагдах хязгаар).

ХАЯАВЧ I гэрийн хаяагаар тойруулан ороох мод, эсгий зэргээр хийсэн хэрэглэл; *модон хаяавч; хаяавч татах.*

ХАЯАВЧ II бөхийн оноо хийхэд зүүн баруун хоёр талын бөхийн оноог хариуцагч; *зүүн хаяавч; баруун хаяавч; хаяавчны бичээч.*

ХАЯАЛ хаяалид.

ХАЯАЛАХ 1. юмны хаяагаар явах; *уул хаяалах;* 2. юмны ярагдаж захлах; *үүл хаяалах; будан хаяалах;* ☆ **муугаа хаяалах** (муу зангаа мэдэгдэж эхлэх).

ХАЯАЛИД төрсөн авга өвгийн ач хөвгүүд, үеэлд ах дүүгийн үр хүүхэд; *хаяалид ах; хаяалид дүү;* **хаяалид хүү** (үеэлд ах дүүгийн хөвгүүн).

ХАЯАЛДАХ хаяалах, холдох; *будан хаяалдах; тэнгэрийн дуу хаяалдах.*

ХАЯАЛУУЛАХ хаяалахын үйлдүүлэх хэв.

ХАЯАРАХ хаяа гарах, гэгээ орох; **үүр хаяарах** (үүр цайж эхлэх).

ХАЯАРУУЛАХ хаяарахын үйлдүүлэх хэв.

ХАЯГ 1. юманд зүүсэн нэрийн пайз тэмдэг; *дэлгүүрийн хаяг; номын хаяг;* 2. захидал, илгээлт зэрэг дээр очих эзний нэр ба газрыг тодорхойлон бичсэн бичиг, гарчиг; *захидлын хаягыйг зөв бичиж явуулсан байв.*

ХАЯГДАЛ хаягдмал, хаягдсан юм; *хаягдал төмөр; усны хаягдал.*

ХАЯГДАС хаягдсан юм; *хаягдас өвдөс; хаягдас угаадас.*

ХАЯГДАХ хаяхын үйлдэгдэх хэв, гэгдэх, орхигдох; *хаягдаж магадгүй, болгоомжил! машинаас хаягдан үлдэв.*

ХАЯГДМАЛ хаягдсан, орхигдсон, гэгдсэн юм; *хаягдмал эд; хаягдмал хог.*

ХАЯГЛАХ I хаягтай болгох; *захидал хаяглах.*

ХАЯГЛАХ II нохой зэрэг амьтан, юман дээр сариад шээсээ булах гэсэн мэт хойт хоёр хөлөөрөө шороо маажлан сацлах; *нохой хаяглах.*

ХАЯГЛАХ III дургүйцэн аяглах, үглэх, зэмлэх.

ХАЯЛАХ байн байн хаях.

ХАЯЛТ хаях үйлийн нэр: **ажил хаялт** (пролетари нарын ангийн тэмцлийн үндсэн хэлбэрүүдийн нэг мөн бөгөөд эдийн засаг, улс төрийн ашиг сонирхлын үүднээс буюу ажилчдын амьдралын шаардлагыг хөрөнгөтнүүдэд тулган хүлээлгэж хангуулах зорилгоор ажилчид зохион байгуулалттайгаар ажлаа орхих).

ХАЯЛЦАХ 1. хаяхын үйлдэлцэх хэв; 2. нэмэлцэх; *үнэ хаялцах;* 3. орхицох, түлхцэх; *бие биедээ хаялцах.*

ХАЯН 1. хоёр бөхийн нэгэн зэрэг унах нь; **хаян болох** (хайнцах, зэрэг унаж хэн ч эс давах); 2. шатар зэрэгт хожилгүй болох нь.

ХАЯНЦАХ 1. хоёр бөх барилдаж нэг зэрэг унах; *хаянцсан хоёр бөх;* 2. шатар, мягман зэрэг тоглоомоор наадахад хэн хэн нь хожилгүй болж тэнцэх.

ХАЯРАХ ингэн тэмээний боосч хаях; *ингэ хаярах.*

ХАЯХ 1. шидэх, чулуудах, таягдах, орхих; *чулуу хаяж орхив; гаргаж хаях; хог хаях;* **цүү хаях** (тоглоом); **яс хаях** (хоёр этгээдийн хооронд үймүүлж өдөөх); 2. гээх, гээгдүүлэх; *түрийвчтэй мөнгөө хаях; замдаа хаяжээ;* 3 орхих, оорох, болих, тэвчих; *тамхиа хаях; ажил хаях;* 4. хээл орхих, дутуу төрөх; *гүү, унагаа хаяж орхижээ;* **ингэ хаях** (ингэн тэмээний бооссоны дараа гавшгай хөнгөн болох; *ингэ хаях*); **гараа хаях** (гараа сажих, савлах); **үг хаях** (гоморхож егөөдсөн үг хэлэх).

ХАЯЦАХ үйл хэргийг бие бие рүүгээ түлхцэх; *хаяцах хэрэггүй, хамжаад бүтээ!*

ХАЯЧИХ хаялах, хаяж орхих.

ХИА урьдын цагт ноёдыг дагалдан үйлчилж явах доод тушаалтан; *ноёны хиа; хиа дагалт; хиа бараа бологч нар;* **хиа лам** (урьдын цагт хутагт хувилгаадын дэргэд дагалдан үйлчлэх доод тушаалтан лам).

ХИАГ у р г а м а л малд сайн тэжээл болдог залаат ургамал; *хиагтай газар; ногоон хиаг.*

ХИАГЛАХ I малыг хиаг өвстэй газар билчээрлүүлэх.

ХИАГЛАХ II харцгай хяргуйн дуугарах.

ХИАМ I у р г а м а л олсны ургамлын төрлийн зэрлэг ургадаг өвс, олс зэрэг зүйл хийдэг; **хиам олс** (муу чанарын олс).

ХИАМ II махыг шанз болгон амталж гэдэс, олгой зэрэгт хийж чанах, утах зэргээр боловсруулсан хоол, колбаса.

ХИАРАХ үлэмжхэнээр үхэх, сүйрэх; *шуурганд мал хиарахад ойрхон байв; өвчнөөр хиарах;* **хиартал хядах** (үлэмжхэнээр алах).

ХИАТАХ 1. хиа болж дагалдах; 2. ш и л ж с э н хүнийг дагаж долдгонон явах, бялдуучлах.

ХИАЧИХ 1. амьтныг олноор алж хядах; *хиачиж дуусах;* 2. мод зэрэг ургамлыг юүртэл огтлох, унагаах; *уулын модыг хиачиж дуусахад ойртов.*

ХИВ маш нимгэн торгомсог эд; *өнгийн хив; хив хадаг; цоохор хив.*

ХИВС дэвсэхэд зориулж нэг талдаа үс татаж хийсэн бүдүүн нэхмэл; *зузаан хивс; нимгэн хивс; хивсэн олбог; гудам хивс; хивс нэхэх; хивсний үйлдвэр.*

ХИВШИХ I энэлэн гасалж гутрах; *хившиж уйлах.*

ХИВШИХ II нүдэж цохиж зөөлрүүлэх; *сур хивших; шир хивших.*

ХИВЭН: хивэн хорхой а м ь т а н авгалдай нь үстэй эдлэл, тариа ургамал зэрэгт хортой нэг зүйл шавьж.

ХИГ усан доторхи замаг мэт юм.

ХИГД: хигд алт будах, зурахад хэрэглэх, цаас мэт боловсруулсан алт.

ХИГТЭР усны доторхи чулуунд наалдаж тогтсон өнгөр мэт ургамал, замаг.

ХИГТЭХ усанд хиг тогтох.

ХИГШИХ хигтэй болох.

ХИГЭЭС хүрд дугуйн тэлүүр; *дугуйны хигээс.*

ХИГЭЭСЛЭХ хигээс гаргах, хигээс хийх.

ХИГЭЭСРЭХ хигээс мэт болох.

ХИЕВЭН монгол олсны ширхгээр нэхсэн нэгэн зүйл бараа.

ХИЕН I у р г а м а л нэгэн зүйл халуун өвс.

ХИЕН II сэтгэлийн санаашрал; **хэнээ хиен** х о р ш.; *санааны хиентэй; хиен болсон амьтан.*

ХИЕН III дан эрчилсэн утасны ширхэг; *хиен утас.*

ХИЕНТЭХ хиен өвчтэй болох.

ХИЖИГ халдварт халуун өвчин; **хижиг тахал** х о р ш.; *хижиг тусах;* **гэдэсний хижиг** (гэдэсний халдварт өвчин, гэдэсний тиф): **бэжрүүт хижиг** (биед бэжрүү туулах халдварт өвчин, бөөсний тиф).

ХИЖИГРЭХ хижиг болох.

ХИЖИГТЭХ хижиг тусах, хижиг өвчин хүрэх.

ХИЖИМ I а м ь т а н далай мөрөнд төрдөг, өт хэлбэртэй нэг зүйл хорхой.

ХИЖИМ II сарлагийн гэдэсний хоёр этгээдээр ургасан хялгас үс.

ХИЖИМДЭХ хижмээс барих.

ХИЖИМЛЭХ хижмий нь хяргаж авах.

ХИЙ 1. газрын агаар мандлыг бий болгогч агаар бие, агаар бодис; *хийн мандал;* 2. алив орчин зайд тэгш дүүрч, эзэлж чаддаг физикийн бие буюу бодис; **хий дүүрэх** (юмны хөндий зайг хий эзлэх); **хий оруулах** (юманд хий хийх, хийтэй болох); 3. дэмий, үргүй; **хий явах** (дэмий явах); **хий үрэх** (юмыг дэмий үрэгдүүлэх; *хайран цагаа хий үрэв);* **хий буу тавих** (зорьсон юмгүй дэмий буудах); 4. хоосон; **хий санаа** (хоосон горьдлого); **хий үзэгдэл** (хоосон үзэгдэл); **хий ханиалга** (цэргүй ханиалга); **хий огих** (бөөлжисгүй огих); **хий эргэх** ,(юмны дугуй хойш урагш өнхрөхгүй тэнхлэгтээ эргэх); 5. чөлөө, зай; **хийгий нь харах** (завсар чөлөөг харах, эзгүй цагийг харах, осол эндэлтэй үгийг харах); **хий орох** (а. хийтэй болох; *дугуйд хий орох;* б. завсар чөлөөгөөр нь ямар нэг юм орох; *хэрэв хий ороогүй бол, заавал бүтэх байсан юм*); ☆ **хий хуй шиг** (маш түргэн зуур; *хий хуй шиг хурдан өнгөрөв*); **хий цохих** (а. салхи цохих, салхинд цохигдох; б. бөхийн мэх; эсэргүүцэл бөхийн хөлийн суурь муутай эндэлтэй байдлыг тохиолдуулан хөлөөрөө товшин цохиж унагаах): **хий мөргөх** (бөхийн барилдаанд барилдах эсэргүүцэл хүнгүй учраас давсанд *тооцогдох,* гэж мөргөх ч гэдэг); **хий ачих** (бөхийн мэх); **хий харгах** (өлсч ундаасан туйлдан үхэтгэх); **хий хөдлөх** (а. өвчин; б. салхи хөдлөх); **хий хөөрөх** (өвчин); **хий морь** (а. цог заль, аз жавхаа; *хий морьтой залуу; хий моригүй;* б. шашны ёсны морь унасан хүний зурагтай нэгэн зүйл дарцаг); **хий морь доройтох** (хэрэг явдал бүтэмжгүй болох; *хий морь нь доройтож, хишиг буян нь зайлах* з ү й р); **хий морь дэлгэрэх** (хэрэг явдал бүтэмжтэй болох); **хий хөлгөт онгоц** (салхи сөрж чадахаар хийсэн онгоц); **хий хоолой** (мөгөөрсөн хоолой).

ХИЙГҮЙ 1. осол эндэлгүй; *хийгүй барилдаг бөх;* 2. зай завсаргүй дотно; *хийгүй нөхөрлөсөн хүмүүс;* 3. агааргүй.

ХИЙГЭЭД бичгийн хэлний холбоос.

ХИЙД шашны ёсны лам нарын хуран суух сүм орон; *Эрдэнэ Зуугийн хийд.*

ХИЙДҮҮЛЭХ 1. хийдэхийн үйлдүүлэх хэв; 2. тасалдуулах; *албан ажлаа хийдүүлэх;* 3. завсар чөлөөг харж гэнэдүүлэн завших; *ахын энэ номыг хийдүүлж байгаад авсан.*

ХИЙДЭХ I тасалдах, эзэнгүйдэх, орхигдох; *ажил хийдэх.*

ХИЙДЭХ II 1. хэтэрхий хийтэй болох; 2. хийрхэх, хий нь дэврэх; 3. завсардах; *хийдэж хоцрох.*

ХИЙЛ 1. дөрвөн чавхдаст, нарийн дуутай хөгжмийн зэвсэг; *хийлээр наадах;* 2. морин хуур.

ХИЙЛГЭХ 1. хийхийн үйлдүүлэх хэв; 2. ш и л ж с э н чадагдах, дийлдэх.

ХИЙЛТ хийх үйлийн нэр.

ХИЙЛҮҮЛЭХ 1. хийлэхийн үйлдүүлэх хэв; 2. хийлэгдэх.

ХИЙЛҮҮР хийлэх багаж.

ХИЙЛЦЭХ хийхийн үйлдэлцэх хэв; *ажил хийлцэх.*

ХИЙЛЧ хийлээр наадагч.

ХИЙЛЭХ 1. хий оруулах, хийтэй болгох; *дугуй хийлэх; гүзээ хийлэх;* 2. хий өвчнөө засахаар тусгай хоол унд хэрэглэн биеэ арчлах; *зутан ууж хийлэх;* 3. бөхийн хий мөргөх; *бөх хийлэх;* 4. хий болгох, хөндийрүүлэх; *сэтгэл хийлэх; газраас хийлэх.*

ХИЙМЭЛ хийсэн юм; *хиймэл цэцэг; хиймэл шүд.*

ХИЙР хиур.

ХИЙРХҮҮ 1. баахан хийтэй; 2. хөөргөн, онгиргон.

ХИЙРХҮҮЛЭХ хийрхэхийн үйлдүүлэх хэв.

ХИЙРХЭХ 1. хий өвчин дэврэх, нэмэгдэх; 2. ухаан солиорох.

ХИЙРЭХ хий болох, хийтэх.

ХИЙСВЭР 1. алив юмны шинж чанарыг ухаан бодлын ёсоор ерөнхийлж ойлгох ойлголт; *хийсвэр ойлголт;* 2. хөнгөн хуумгай зан; **хөнгөн хийсвэр** х о р ш.; *хөнгөн хийсвэр зантай.*

ХИЙСВЭРДҮҮ хэтэрхий хийсвэр байдалтай.

ХИЙСВЭРДҮҮЛЭХ хийсвэрдэхийн үйлдүүлэх хэв.

ХИЙСВЭРДЭХ хэтэрхий хийсвэр болох, хийсдэх.

ХИЙСВЭРЛҮҮЛЭХ хийсвэрлэхийн үйлдүүлэх хэв.

ХИЙСВЭРЛЭХ хийсвэр болох, хийсвэр байдал гаргах.

ХИЙСВЭРХЭН нилээд хийсвэр.

ХИЙСГЭХ хийсэхийн үйлдүүлэх хэв; *салхинд үнс хийсгэх; хийсгэвэл тэнгэрийн дур, хэлбэл ноёдын дур* з ү й р; **цагаа хийсгэх** (нүдэнд унасан үүлийг арилгах); **хөрөнгий нь хийсгэх** (бүх хөрөнгийг хураах); **хийсгэн талах** (эд хөрөнгийг дээрэмдэн талах).

ХИЙСДҮҮ хийсвэрдүү.

ХИЙСДЭХ хийсвэрдэх, хийсдүү байдал гаргах.

ХИЙСЭХ юмны хүчинд хөөрөн хөдлөх; *салхинд туг хийсэх; шороо хийсэх; үлээхэд хийсэх; хог хийсэх*; **нүдний цагаа хийсэх** (нүдний цагаа арилах); **хөрөнгө хийсэх** (хөрөнгө барагдаж арилах).

ХИЙТЭЙ 1. хий бүхий; *хийтэй дугуй;* 2. гэнэн, осолтой; *хийтэй бөх;* 3. хий өвчтэй; **хийтэй нохой** (галзуу нохой).

ХИЙТЭХ хий нь улмаар нэмэгдэх.

ХИЙХ 1. үйлдэх, бүтээх; *ажил хийх; хурал хийх; ажил хийвэл дуустал, давс хийвэл цустал* з ү й р: **сургууль хийх** (сурахын тул ажиллаж оролдох); **цай хийх** (а. цай боловсруулан үйлдэх; б. цай чанах; в. цай аягалах); **хоол хийх** (а. хоол боловсруулан бэлтгэх; б. хоол тэжээл болгон хэрэглэх; *би дан ногоогоор хоол хийж чадахгүй юм);* **гэм хийх** (буруу гажуу хэрэг үйлдэх); 2. юмыг сав суулга зэрэгт агуулах; *авдарт хийх; хувинд хийх; усанд хийх; хашаанд хийх;* **давс хийх** (а. хоол унданд давс тохируулан орхих; б. юманд улам нэрмээс болох үйл үйлдэх; *дайрин дээр нь давс хийх);* 3. хувцас, эдлэл өмсч зүүж хэрэглэх; *бээлий хийх; чихэвч хийх; ээмэг хийх; бөгж хийх;* 4. хэрэгцээнд зориулж ямар нэгэн юм бий болгох, бэлдэх; **бэл хөрөнгө хийх** (эх үүсвэр хөрөнгө болгох): **гар хөл хийх** (өөрийн үйл хэрэгт хань хамсаа болгох); **хүн хийх** (сайн хүн болгож хүмүүжүүлэх); **хань хийх** (хань хамсаа болгох); **мод хийх** (а. ургаа модыг огтолж хэрэгцээнд бэлдэх; б. мужаан хийх); **идэш хийх** (идшинд зориулж мал нядлах); **мал хийх** (а. мал болж чадахгүй амьтныг мал болгохоор арчлах; б. мал алж нядлах): ☆ **ял хийх** (ял шийтгэх, ногдуулах); **саад хийх, садаа хийх** (тотгор учруулах); **алдаа хийх** (осол эндэл гаргах); **тоглоом хийх** (даажигнах).

ХИЙХИЙ үлэмж инээх байдлыг үзүүлэх аялга үг; *хийхий хахаа болох;* **хийхий хахаа** (их л хөхрөх байдал).

ХИЙЦ I хийсэн янз үзэмж, чанар байдал; *хийц сайтай; хийц муутай.*

ХИЙЦ II 1. хуурай идэшний зүйл; *аяганы хийц ихтэй явахад зүгээр шүү;* 2. хийцэлсэн нь; *хийцтэй цай.*

ХИЙЦЛҮҮЛЭХ 1. хийцлэхийн үйлдүүлэх хэв; 2. хийцлэгдэх.

ХИЙЦЛЭХ I уушны зүйлийг зутагнаж чанаржуулах; *цай хийцлэх.*

ХИЙЦЛЭХ II бусдыг гэнэдүүлэн залилах; *би түүнийг сайн хийцлэв.*

ХИЙЧИХ хийж орхих; *би хийдэг ажлаа хийчихсэн.*

ХИЛ I нутаг, газар орны хоорондын зааг, сав; **хил хязгаар** х о р ш.; *улсын хил;* **хилийн овоо** (хилийн тэмдэг овоо);**хилийн цамх** (хилийн тэмдэг): **хилийн харуул** (хил хязгаарыг сэргийлэн суулгасан цэрэг); **хил хамгаалагч** (хил сэргийлэх үүрэг бүхий хүн); **хил нэвтрэх** (хязгаар давах); **хил нийлэх, хил залгах** (нутгийн зах хязгаар уулзах); **хилийн будлиан** (хил хязгаар зөрчсөний улмаас гарсан будлиан); **хилийн шугам** (хилийн зааг).

ХИЛ II хөгжмийн чавхдас хөрөөдөх нум.

ХИЛЛЭХ 1. нутгийн хил хязгаар залгах; 2. савлах II.

ХИЛС ташаа, мушгиу, буруу; *хилс гүжир; хилс хэрэгт холбогдох;* **хилс явдал** (ташаа буруу болсон явдал).

ХИЛСГҮЙ 1. хилс биш, үнэн, лав, магад; *хилсгүй хэрэгт холбогдов; хилсгүй үнэн юм;* 2. шудрагагүй, хилс гүжир, мушгигдуу, ташаа.

ХИЛСДҮҮЛЭХ хилсдэхийн үйлдүүлэх хэв.

ХИЛСДЭХ хилс болох, хилс учир нэрвэгдэх, мушгигдах, ташаа, буруу хэрэгт холбогдох.

ХИЛЧИН хил хязгаарыг хамгаалагчид.

ХИЛЭГНҮҮЛЭХ хилэгнэхийн үйлдүүлэх хэв.

ХИЛЭГНЭХ хилэнлэх.

ХИЛЭМ а м ь т а н мөрөн голд төрөх нэгэн зүйл загас, мах болон түрс нь сайн,

ХИЛЭН I хөвөн мяндас зэргээр нэхэж хийсэн нэгэн зүйл үсэрхэг бараа; **хамба хилэн** (нарийн сайн хилэн); **ямаан хилэн** (тачир үстэй хилэн); **битүү хилэн** (бүдүүвтэр хилэн); **тансар хилэн** (савх мэт урт судалтай хилэн).

ХИЛЭН II уур, урин: **урин хилэн, уур хилэн** х о р ш.; **хилэн төрөх** (уурлах).

ХИЛЭН III хирс.

ХИЛЭН IV дурс гуужсан мод; **хилэн хожгор** (огт үсгүй, ургахгүй хожгор).

ХИЛЭНЛЭХ хилэн төрөх, уурлах, хилэгнэх.

ХИЛЭНЦ нүгэл, буруу муу үйл; **нүгэл хилэнц** х о р ш..

ХИЛЭНЦЭТ хилэнц бүхий, хилэнцтэй; **хилэнцэт хорхой** а м ь т а н (цэнгэг ус буюу далайд орших, биедээ эвэрлэг бүрхүүлтэй, толгойн орчинд зуух хөлтэй амьтан, бас ямаан ууц, дигбаранз гэж нэрлэнэ).

ХИМ I ясны доторхи нүх, сархиаг болон тогтсон хэсэг; *ясны хим.*

ХИМ II у р г а м а л 1. монгол амуу шиг болоод баахан үлбэгэр, дүгрэг том навчтай, ногоон иштэй нэгэн зүйл ургамал; 2. энэ ногооны ишнээс хуулж авсан, хальсаар боловсруулсан нэг зүйл муухан олс.

ХИМ III ан амьтан, загас зэргийн махыг хярж амт нийлүүлэн түүхийгээр идэх хоол.

ХИМИ материйн дотоод бүрэлдэхүүн, дотоод бүтэц, бодисын чанарын өөрчлөлтийн зүй тогтоол хийгээд түүний задрал, хувирал, түүнчлэн чанарын өөрчлөлтийн эцэст үүсэх шинэ бодис тогтох зүй тогтоолыг судлах, байгалийн шинжлэлийн үндсэн нэг шинжлэх ухаан; *химийн ухаан; химийн урвал; химийн лаборатори; химийн үйлдвэр;* **органик бус хими** (химийн махбодын чанар, тэдгээрийн хувирал нэгдлийг судлах ухаан); **органик хими** (нүүрс төрөгчийн нэгдэл хийгээд бусад энгийн нэгдлийг судлах ухаан).

ХИМИЧ химийн ухааны мэрэгжилтэн.

ХИМРЭХ хим болох; *яс нь химрэх.*

ХИМШИХ химтэй болох, хим шинжтэй болох.

ХИН ятга гэдэг хөгжим.

ХИНЭ нойтон газар бүрж тогтох ногоовтор өнгөр, хөгц.

ХИНЦИЙХ үл тааламжлан нүдний буланаар хялайж харах; *хинцийн үзэх.*

ХИОСГОН саармаг хүн, манин.

ХИР I 1. чинээ, чадал; **хир хир** (чингэх нь аргагүй, чинээндээ тулжээ, чадал нь тэр); *чадахын хирээр хийх; мэдэхийн хирээр хэлж өгөх; хирээ мэдэх;* **хирээс хэтрэх** (чадлаас хэтрэх); 2. аль, ямар, зэрэг; *хир зэргийн эд вэ? хир олон хүн байна вэ? аль хир өндөр вэ?* 3. үе, үес, орчим; *үдийн хирд; шөнө дүлийн хирд; одоо хирдээ завгүй байна; энэ хир хөдөө явахгүй;* 4. энгийн, ерийн, бараг; *хиртэй хүн чадмаргүй; хиртэй морь гүйцмээргүй хурдан;* **хирийн юм** (ерийн, барагтай, бага сага юм); **хиртэй бол чингэхгүй** (барагтай бол чингэхгүй); 5. хөрөнгө чинээ, өв хөрөнгө; *хирээ мэдэж бяраа тань* з ү й р; **хирийг дагах** (өвөө сахиж ангижрахгүй); **хир олохгүй, хиргүй** (хөрөнгөө эзэмшиж чадахгүй); **хирээр** (чадах чинээгээр; *хирээрээ ажиллах; хүн хирээрээ, тэмээ тэнгээрээ; чадлын хирээр хийж, хэрэглэхийн хирээр авах; хөнжлийн хирээр хэлөө жийх, адууныхаа хирээр исгэрэх* з ү й р.

ХИР II 1. буртаг; **хир буртаг** х о р ш.: *хувцасны хир; хумсны хир;* **өлөн хир** (а. шөнийн хир; б. хувцас хунарт суусан ялимгүй хир); **нарийн хир** (хувцсанд суусан багахан хир); **бүдүүн хир** (хувцсанд суусан ихээхэн хир); 2. ш и л ж с э н дутагдал, бал хал; *түүнд хэлсэн нь огт хир халдаахгүй байна билээ;* **хир хорхой** а м ь т а н (худгийн усанд төрөх бяцхан улаан хорхой).

ХИРВЭЭС үст эдээр хийсэн хажлага, мөшгөөр; **хирвээст малгай** (үстэй юмаар хирвээслэн хийсэн, сөхдөггүй бяцхан малгай).

ХИРВЭЭСЛЭХ дээл хувцасны хормой буюу энгэрийг тойрон үсээр мөшгөрлөх, хирвээс хийх.

ХИРГИСҮҮР эрт дээр цагт үхэгсдийн хүүрийг оршуулсан булш).

ХИРГУУЦАЙ а м ь т а н бүргэд, хараацай, хяргуйн дундаас төрсөн шувуу.

ХИРГҮЙ 1. хир буртаггүй цэвэр; *хиргүй хувцас;* 2. өө сэв, гэм осолгүй; *хиргүй сэтгэл; хиргүй үйл.*

ХИРДХИЙЛГЭХ хирдхийхийн үйлдүүлэх хэв.

ХИРДХИЙХ юмнаас айн хэлмэж дотор сэр хийх, шижигнэх, эмээж сочих; *хирдхийн сочих; дотор хирдхийв.*

ХИРЛҮҮЛЭХ 1. хирлэхийн үйлдүүлэх хэв; 2. хирлэгдэх.

ХИРЛЭХ 1. юмыг барагцаалан хэмжих, багцаалж төлөвлөх; 2. чадлаа бодох, чинээгээ бодох; *чи ер нь хирлээрэй.*

ХИРЛЭШГҮЙ 1. тооны нэр, арван өгүүлшгүй, жаран гурван тэгтэй тоо; 2. хэмжээлж хязгаарлаж болшгүй, санашгүй.

ХИРС а м ь т а н хамар дээрээ нэг буюу хоёр эвэртэй, сүүн тэжээлт амьтан.

ХИРСЭХ амьтны хярж хөдлөхгүй болох.

ХИРСЭЭХ хирсэхийн үйлдүүлэх хэв.

ХИРТҮҮЛЭХ хиртэхийн үйлдүүлэх хэв.

ХИРТЭЙ I багцаа, тойм, бараглал, хэмжээ, хирээтэй; *аль хиртэй; таван метр хиртэй; хориод хиртэй; хиртэй бай.*

ХИРТЭЙ II хир буртагтай; *хиртэй цамц.*

ХИРТЭЛ хиртэх үйлийн нэр.

ХИРТЭЛТ хиртэх байдал.

ХИРТЭМТГИЙ хиртэхдээ хялбар, хиртэмхий.

ХИРТЭМХИЙ хиртэмтгий.

ХИРТЭХ 1. хир буртаг болох; 2. хирлэх; *нар хиртэх.*

ХИРТЭЭХ хиртэхэд хүргүүлэх.

ХИРУРГИ мэс засал.

ХИРУРГИЧ мэс засалч.

ХИРХРЭХ 1. хирхрээ өвчнөөр өвдөх; 2. хирчигнэн дуугарах.

ХИРХРЭЭ цээж хирчигнэн, амьсгал дэмхцаж сүйлгэлэх өвчин.

ХИРЦЭХ барагцах, барагцаалах.

ХИРЦЭЭ барагцаа, багцаа.

ХИРЧЭЭ хэрчээ.

ХИРЭЭ хэмжээ; **хэмжээ хирээ** х о р ш.; *хэмжээ хирээгүй их.*

ХИСМЭС: хисмэс үзэм дотроо үргүй ногоон үзэм.

ХИТЭГ суман онгоцны хойт тал: **хитэг барих** (онгоцыг сүүлийн залууураар залах).

ХИУР жижиг дарцаг, салхинд хийсгэх дөрвөлжин, гурвалжин хэлбэрийн хэсэг бөс; ☆ **хиур хорхой** а м ь т а н (бие шаравтар, жигүүр явцуу урт, жигүүр бие маш зөөлөн, загасны өөшинд хэрэглэнэ).

ХИУРМАГ жижигхэн хайр чулуу; **өнгөт хиурмаг** (барилгын хэрэгцээнд зориулан жижиглэсэн өнгөт хайр чулуу).

ХИУРС бөөсний саг, өндөг.

ХИХИЙ: хихий луус гүүнээс төрсөн луус.

ХИЧ юнгар гэдэг халуун чанартай ургамлын үр.

ХИЧИР нумны хоёр үзүүрийн бэлчинд өмхүүлэн хадсан мод; *нумны хичир; юманд учир бий, нуманд хичир бий* з ү й р; **хичир заадаслах** (нумны их биед хичир нийлүүлэн цавуудах).

ХИЧИРЛЭХ нуманд хичир хийх.

ХИЧЭЭЛ I хичээх үйлийн нэр, чармайлт, шамдлага, идэвх оролдлого; **идэвх хичээл** х о р ш.; *хичээл сайтай сурагч; эрлийг сурлаар эрдмийг хичээлээр* з ү й р.

ХИЧЭЭЛ II тогтоолтой цагт хийж байгаа сургууль; *хичээл найман цагт эхэлнэ; хичээлийн дараа болох; бид хичээлтэй байна; хичээл заах; хичээлийн эрхлэгч; хичээлийн жил; хичээлийн цаг.*

ХИЧЭЭЛГҮЙ идэвх шамдлагагүй.

ХИЧЭЭЛГЭХ хичээхийн үйлдүүлэх хэв, хичээхэд хүргүүлэх.

ХИЧЭЭЛЛҮҮЛЭХ хичээллэхийн үйлдүүлэх хэв, хичээл хийлгэх.

ХИЧЭЭЛЛЭХ хичээл хийх; *бид найман цагаас эхэлж хичээллэнэ.*

ХИЧЭЭЛТЭЙ I 1. хичээвэл зохилтой, улайж шамдах ёстой; 2. хичээл сайтай, хичээнгүй, чармайлттай, оролдлоготой; *хичээлтэй сурагч.*

ХИЧЭЭЛТЭЙ II хичээл сургууль бүхий.

ХИЧЭЭНГҮЙ нягт, нямбай, хянамгай, болгоомжтой; *хичээнгүй хүн;* ☆ **хичээнгүй үсэг** (үсгийн зураг дүрийг тусгайлан сонгон гоёосон хэлбэр дүрмийг журамлаж бичсэн үсэг).

ХИЧЭЭНГҮЙЛЭХ хичээнгүйгээр зүтгэх, чармайн зүтгэх; **хичээнгүйлэн ёслов** (хүндэтгэлийн үг).

ХИЧЭЭНГҮЙТЭЙ болгоомжтой, хянамгай, нягт.

ХИЧЭЭНГЭ 1. хичээнгүй; 2. шамдлага сайтай, зүтгэл ихтэй.

ХИЧЭЭНГЭДЭХ хэтэрхий хичээнгэ болох.

ХИЧЭЭХ шамдаж чармайх, идэвх оролдлого гаргах, санаа тавих; *хичээгээрэй базаагаарай! хичээж уулзаад ирээрэй; хичээвэл бүтнэ; амь хувиа хичээх.*

ХИШИГ I 1. өглөгийн хүндэтгэл; хишиг өгөх; *хишиг хүргэх;* 2. ногдсон хувь; *амны хишиг; буян хишиг.*

ХИШИГ II 1. Ням гараг; *хишиг өдөр;* 2. ээлж; *энэ өдөр манай хонины хишиг.*

ХИШИГТЭН 1. Өвөр монголын нэгэн аймаг; *хишигтэн хушуу;* 2. хишиг бүхий хүмүүс.

ХИЮУ хэвгий, хазгай.

ХИЮУД Боржгин; **хиюуд ястан** (боржгид овогтон).

ХЛОР химийн махбод, амьсгал бахардуулах хий, техник, эмнэлэг зэрэг зүйлд хэрэглэнэ; *хлорын шохой.*

ХЛОРТ хлор бүхий, хлортой; *хлорт кальц.*

ХЛОРТОЙ хлорт.

ХЛОРТОЙВТОР багавтар хлортой, жаахан хлортой.

ХЛОРФОРМ хлор бүхий, өнгөгүй, ширгэмтгий шингэн.

ХО хүнд хөнгөний хэмжээ, фунг зуу хуваасны нэг (3,75 миллиграмм).

ХОВ I хүний хооронд муутган хэлэх үг, завсардуулах үг; **хов шив, хов жив** х о р ш.; *ховын үг; хов хөвцөлдөх; хов шив хэлсээр хүнээ барна, ихэр шихэр идсээр юмаа барна* з ү й р; **хов зөөх** (хов хэлэх).

ХОВ II хүч нэмэгдүүлэх үг; **хов хоосон** (огт юу ч үгүй).

ХОВД I урт нарийн юм агуулах уртуулаг хайрцаг; *сумны ховд; хүжний ховд.*

ХОВД II малын ноосыг мушгиж хэсэг хэсгээр эрчлээд, тэдгээр хэсгүүдээ хамтатгаж нэгэн урт мушгимал ноосоор ороож хийсэн цхээхэн бөөн хэсэг; *ховд унгас.*

ХОВДЛОХ I ховдод агуулах.

ХОВДЛОХ II унгас ноосыг ховд болгох.

ХОВДЛУУЛАХ ховдлохын үйлдүүлэх хэв.

ХОВДОГ 1. идэх уухад хомхой, шунахай, дав дээр цадах ханахгүй; *ховдог идэх; ховдог хүн; ховч хүн үгэнд, ховдог хүн хоолонд* з ү й р; 2. ш и л ж с э н юманд шунахай, авлигач; *ховдог шунахай төрөнгөтнүүд.*

ХОВДОГДОХ дэндүү ховдог болох.

ХОВДОГЛОХ ховдог зан гаргах, шунах, авлигалан авах идэхийг бодох; *ховдогложс байгаад эд бараа хэтэрхий их хуримтлуулсан байв.*

ХОВДОГЛУУЛАХ ховдоглохын үйлдүүлэх хэв.

ХОВДОГРОХОГ ховдог, шунахай.

ХОВДОГРОХОХ ховдог зан гаргах, шунах.

ХОВДОГХОН нилээд ховдог.

ХОВДОЛ ховил,; ховдол гаргах; **зүрхний ховдол** (зүрхний нэг хэсэг, цусан судлаар явж буй цусны хөдөлгөөнийг зохицуулна).

ХОВДОС хүн шиг толгойтой, хонь шиг биетэй, сугадаа нүдтэй нэг зүйл, үлгэрийн амьтан.

ХОВИЛ 1. юманд янз маяг болгон мөчидхөн хонхойлж ухах багаж; **ховил ховхи** х о р ш.; 2. юманд янз болгон мөчидхөн гаргасан уртааш дагуу нарийн хонхор; *хутганы ховил; ховил гаргах.*

ХОВИЛДОХ ховил гаргах.

ХОВИЛДУУЛАХ ховилдохын үйлдүүлэх хэв.

ХОВЛОХ хов хэлэх; *ховловол бутрах, зөвлөвөл бутэх.*

ХОВЛУУЛАХ 1. ховлохын үйлдүүлэх хэв; 2. ховлогдох.

ХОВОЛ I у р г а м а л улаан буюу хар жимгэнэтэй бут мод; **нүцгэн ховол** у р г а м а л (навч туурын навчтай адил болоод өргөн урт, зулам дурсаар нумын бариул, хутганы хүй хулдвал болно).

ХОВОЛ II нарийн уртуулаг хонхор; **ховол хонхор** х о р ш..

ХОВОО ус татах хэрэгсэл; *худгийн дэргэд ховоо харагдав; ховоогоор ус татаж малаа усалж байв.*

ХОВООДОХ ховоогоор ус татах.

ХОВООДУУЛАХ ховоодохын үйлдүүлэх хэв.

ХОВОР элбэг гэдгийн эсрэг утга, чухал, элбэг биш, бага, цөөн; **ховор живэр** х о р ш.; *ховор тохиолдох явдал; энд гахай ховор; манай нутагт элстэй тал ховор;* **ховор өлгөлөн** (идэш ховор); **ховор жил** (идэш ховор жил);

ховор хулгана амьтан (туулай мэт толгойтой, сүүлэндээ үстэй, хүн шиг зогсч чаддаг, томоохон мэрэгч амьтан).

ХОВОРДОХ 1. хэтэрхий ховор болох, цөөшрөх, элбэг биш болох; *өвөл болж жимс ногоо ховордов;* 2. хэтэрхий бага хэмжээтэй, богино, давчуу болох; *бие нь өсөөд дээл нь ховорджээ.*

ХОВОРДУУ баахан ховор, ховровтор.

ХОВОРДУУЛАХ ховордохын үйлдүүлэх хэв.

ХОВОРХОН нилээд ховор.

ХОВОРШИГ ховордуу, ховор мэт.

ХОВОРШИХ ховор болох, ховор шинжтэй болох; *ховоршсоор ховоршсоор бүр алга болох; сүү ховорших.*

ХОВОРШУУЛАХ ховоршихын үйлдүүлэх хэв.

ХОВРОВТОР арай ховор, ховордуу.

ХОВС I 1. зэрлэг гахайн хоёр настай тоорой; 2. бяцхан, тэжээвэр эр гахай.

ХОВС II илбэ, бааш: **илбэ ховс** хорш..

ХОВСДОХ илбэ ховс үзүүлэх.

ХОВСЛОХ илбэ ховс гаргах.

ХОВСОРГОН ховсрох зантай; *ховсоргон хүн.*

ХОВСОРЧ ховсрохдоо чадамгай.

ХОВСРООЧ хоёр тийш ховлон үймүүлж явдаг заншилтай хүн, ховч.

ХОВСРОХ хоёр тийш ховлох, хүний хоорондхов зөөж үймүүлэх.

ХОВХ I амьтан усны ёроолоос ангижирдаггүй маш бүдүүлэг нэгэн зүйл загас.

ХОВХ II хүч нэмэгдүүлэх үг; *ховх татах; ховх цохих;* **ховх сорох** (хэтэрхий уухыг шоодох үг).

ХОВХИ юмыг матруулан хуйлах, хонхойлгон ухах зэргээр нэг талыг хотгор болгосон багаж; *ховхиор засах; ховхи харуул.*

ХОВХИДОХ ховхиор засах.

ХОВХИДУУЛАХ ховхидохын үйлдүүлэх хэв.

ХОВХИЛ суваг мэт ухагдсан нарийн хонхор зам; *замын ховхил.*

ХОВХИНОХ ийш тийш үймцэн гүйлдэх; *тар битгий ховхиноод бай!*

ХОВХЛОХ ховхроход хүрүүлэх, ховхруулах, наалдсан барилдсан юмыг салгах, ангижруулах; *шигтээ ховхлох; хөрзөн ховхлох.*

ХОВХЛУУЛАХ ховхлохын үйлдүүлэх хэв.

ХОВХОРХОЙ ховхорсон юм.

ХОВХРОХ I юмны наалдсан барилдсан газраас салж, хуурч ангижрах; *наалдуулсан цаас нь ховхорчээ;* **цэр ховхрох** (ханиахад цэр гарах болох).

ХОВХРОХ II хуучирсан эхнэрийн эрдээ хаягдах, гээгдэх.

ХОВХРУУЛАХ ховхрохын үйлдүүлэх хэв.

ХОВХЧИС халцгай.

ХОВХЧИХ олныг ховлох, байн байн ховхлох.

ХОВХЧУУЛАХ ховхчихын үйлдүүлэх хэв.

ХОВЧ хов зөөх зантай; *ховч хүнд нөхөргүй, худгийн усанд загасгүй* зүйр.

ХОВЧДОХ дэндүү ховч болох.

ХОВЧХОН баахан ховч.

ХОВШИХ яриа нь хэтрэх, дэндэх.

ХОВШУУР орсон гарсан хүнийг анзаарахгүй үхэлдэн ярьдаг хүн; *ховшуур өвгөн.*

ХОГ I 1. новш, хаягдал, ямар нэгэн юмны үл хэрэглэгдэх үлдэгдэл; **хог новш, хог буртаг** хорш.; *хогийн хайрцаг;* **хогийн лүү** (юм бүхнийг багтааж байх сав мэт); **хог тарих** (хогтой болгох); 2. шилжсэн үлдэгдэл, эд агуурс, хөрөнгө хогшил; *хогтой айл;* 3. хэмхдэг, үйрдэс, хаягдал; *талхны хог; чихрийн хог;* 4. муу, муухай юм; **хог саг** хорш.; *хогийн эд;* ☆ **хог цөв** (тосны цөв).

ХОГ II: **хог хийх** гэнт нойр хүрэх, **нүд анилдах.**

ХОГГҮЙ I хог новшгүй.

ХОГГҮЙ II үлдэлгүй, бүрмөсөн, **бүгд, цөм;** *өвчин хоггүй эдгэх.*

ХОГЖРОХ холцрох, ховхрох, хуурах.

ХОГЖРУУ арьсны эвэрлэг эс тослог хөөрөөс бүтсэн жижиг бужигнасан зүйл; *хогжруу унах; ярны хогжруу.*

ХОГЖРУУЛАХ хогжрохын үйлдүүлэх хэв.

ХОГЖРУУТАХ хогжруутай болох; *толгой хогжруутах.*

ХОГЖРУУТУУЛАХ хогжруутахын үйлдүүлэх хэв.

ХОГЛОХ малын хээр билчээрлэн идэшлэх.

ХОГЛУУЛАХ хоглохын үйлдүүлэх хэв; мал идэшлүүлэх.

ХОГРОХ хог нунтаг болох.

ХОГТОЙ I хог новштой.

ХОГТОЙ II үлдэлтэй, цаанаа юмтай, хоосон биш.

ХОГТОХ хог ихтэй болох.

ХОГЧ (ИН) хог цэвэрлэгч.

ХОГШИЛ 1. гэр, албан тасалгаанд тавих авдар, шургуулга, ширээ зэрэг эд юмс; *гэрийн хогшил; хогшил сайтай тасалгаа; сангийн эд хогшил; эд хогшлын данс;* 2. эд агуурс, хөрөнгө зөөр; *хогшилтой айл.*

ХОГШИЛЖИХ хогшил ихтэй болох.

ХОГШИЛЖУУЛАХ хогшилжихын үйлдүүлэх хэв, хогшилтой болгох.

ХОГШИХ I хог ихтэй болох, хог шинжтэй болох.

ХОГШИХ II эд агуурсаар элбэгжих, дэгжих, хөрөнгөжих, хогшил хөрөнгөтэй болох.

ХОД I саадгүй, ноцогдолгүй; *ход гүйх.*

ХОД II үргэлж, байнга; *ход хэвтэж байдаг.*

ХОД III хүүхдийн инээх зэргийг өгүүлэх аялга үг; *ход ход хийх.*

ХОДООД (ОН) I идээ хоол боловсруулах, булчингаар бүтсэн уут мэт эрхтэн; *ходоод муудах; ходоодны шүүс; малын ходоод; ходоодоо идэхэд хоёул болоосой, хонио хариулахад хоёул болоосой* с э ц э н үг.

ХОДООД II загас барих бургас мэтээр сүлжиж хийсэн нэгэн зүйл тор, нэгэнт орсон загас буцан гарч үл чадна.

ХОДХИЙХ ухасхийх, давхийх.

ХОЁР нэг дээр нэгийг нэмсэн тоо; *хоёр хоногоод ирэх; та бид хоёр явна; хоёр хүн хэдий хол болович учрах, хоёр хад хэдий ойр болович үл учрах* х у у ч.; **хоёрын хооронд** (гүйцэд биш, дутуу; *хоёрын хооронд нэг бага юмаар юу хийх вэ; хоёрын хооронд гурвын дунд);* **хоёр чавхдаст** (янз шудрага хөгжимтэй адилхан болоод модон цагариг нь уртхан өнцөгтэй, дотоод тал хөндий, хоёр чихэнд чавхдас торгож хуурдах хөгжмийн зэвсэг); **хоёр тал** (а. нэг юмны хоёр этгээд; б. нэг юмны хоёр хэсэг; в. хоёр хэсэг хуваагдсан; г. хоёрдмол; *хоёр талтай шийдвэр);* **хоёр буудалт нисэх онгоц** (нисэх онгоцны нэгэн зүйл, дороо дугуйтай онгоц бий тул газар усны алинд ч бууна); **хоёр нүдний дуран** (алс байгаа юмыг харахад зориулж нүдэнд тохируулан хоёр хоолойг холбож хийсэн хараа зүйн багаж): **хоёр нүүртэн** (эсрэг тэсрэг хоёр этгээдэд үнэнч байдал гарган тал засч, тэгш үйлчлэгч); **хоёр гартай** (аливаа юм үйлдэж хийхдээ сайн муу хийдэг заншилтай; *тэр гуай ч хоёр гартай хүн байгаа юм);* **хоёр яс хагацах** (салах); **арьс яс хоёр** (маш туранхай); **хоёр төлөв** (арга бэлэг хоёр хоёул тэс өөр боловч хослон дуудаг тэнгэр газар, нар сар, халуун хүйтэн, эр эм гэх мэт зүйлс); **хоёр шарга** з у р х а й Алтан гадас одны ойр орших, хоёр том одны нэр, Тайж од Хаан од хоёр ч гэнэ); **хоёр нутагт** (сээртэн амьтны анги, мэлхий, салмандар зэрэг цөм багтана, зулзага нь загастай адил заламгайтай, том болсон хойноо сая уушгаар амьсгана); **хоёр амт хорхой** а м ь т а н (бүсдын шимийг сорон амьдрагч хорхой, сээртэн амьтны гэдсэнд амьдрана, хоёр үзүүртээ сорох соруултай).

ХОЁРДОХ 1. сэтгэл санаа нэгэн чигт тогтуурихгүй, тээнэгэлзэх; *сэтгэл хоёрдох;* 2. хоёр дахих, давхардах: **хоёрдон гуравдан** (ямар нэг юмны шийдвэр чиглэл, үг утгын зэрэг зүйлийг нэгэнт_ийм болгоё гээд бас дахин давтан өөрчилж хоёр гурван өөр болгох).

ХОЁРДОХЬ хоёрдугаар; *хоёрдахь өдөр; хоёрдохь хоног; хоёрдохь ээлж.*

ХОЁРДУГААР дэс тооны хоёрт тохиолдсон нь; *хоёрдугаар сар; хоёрдугаарт орох.*

ХОЁРДУУЛАХ хоёрдохын үйлдүүлэх хэв.

ХОЁРЛОХ 1. хоёр болгох; 2. сэтгэл хоёрдох, хоёр янзаар бодох, сэтгэл хуваарилах; 3. хоёр дахих, давхарлах.

ХОЁРЛОХГҮЙ хоёр санаа агуулахгүй.

ХОЁРЛУУЛАХ хоёрлохын үйлдүүлэх хэв.

ХОЁРТ 1. хоёр тоо бүхий; 2. хоёрдугаарт.

ХОЁРТАА хоёр удаа.

ХОЁРТОЙ 1. хоёр бүхий; 2. хоёр настай; *хоёртой хүүхэд.*

ХОЁРТОХ хоёр болох; *юм хоёртож харагдах.*

ХОЁРТУУЛАХ хоёртохын үйлдүүлэх хэв.

ХОЁРХОН дөнгөж хоёр, хоёрын төдий; *дөнгөж хоёрхон ажилчин байна; хоёрхон цаг суугаад тарна.*

ХОЁУЛ (АН) хоёр юмны хамт ахуй; *та хоёр хоёул нааш ир! хоёул хамт явъя; хоёул хоёул очихын хэрэг алга.*

ХОЁУЛХАН зөвхөн хоёул.

ХОЖГОР толгойд үс ургахгүй болсон нь; *хожгор толгойтой; долоон хожгор, нэг можгорын үлгэр;* ☆ **хожгор яр** (толгойд гарч үс зулгаран унах нясуу яр).

ХОЖДОМТГОЙ дандаа хожиддог.

ХОЖДООХ хождуулах, хождоход хүргүүлэх.

ХОЖДОХ хожимдох, оройтох; *нөхдөөсөө хождох; хугацаанаас хождох; ажилдаа хождох;* **чи хожид** (дуугүй бай!).

ХОЖДУУЛАХ хождохын үйлдүүлэх хэв.

ХОЖИГДОХ хөнжигдох, дийлдэх, давагдах; *хожсон хожигдсон хоёр баг.*

ХОЖИГНОХ хоржигнох; *ус хожигнох.*

ХОЖИД урьд гэдгийн эсрэг утга, хожим **урьд хожид** х о р ш.; *урьд хожид үзэгдээгүй явдал.*

ХОЖИЙЛГОХ хожийхын үйлдүүлэх хэв, хожгор болгох.

ХОЖИЙХ 1. хожгор болох; 2. мод ургамал ховор болох.

ХОЖИМ хойно, сүүлд, дараа; **хожим хойно** х о р ш.; *хожим уулзахад нүүр бардан; хожмын явдал.*

ХОЖИМДОЛ хожимдох үйлийн нэр.

ХОЖИМДОХ хождох, хоцрох; *хожимдож ирэх.*

ХОЖИС тэжээвэр тахианы өөр нэр.

ХОЖИХ хонжих; *би хожих шахаж байна.*

ХОЖОО хонжоо.

ХОЖООЧ хонжооч.

ХОЖУУ хоцронгуй, хожимдож яваа, сүүлд; *хожуу ирэх; хожуу мэдэх.*

ХОЖУУДАХ хэтэрхий хожуу болох, сүүлдэх.

ХОЖУУДУУЛАХ хожуудахын үйлдүүлэх хэв.

ХОЖУУЛ газарт үлдсэн модны уг; *модны хожуул дээр сандайлан суув.*

ХОЙ живэг загасны зулзага.

ХОЙГ хагас арал, нэг талаасаа хуурай газартай, бусад гурван талаасаа усаар хүрээлэгдсэн хэсэгхэн газар; *Крымийн хойг; Камчаткийн хойг.*

ХОЙГУУР 1. хойт этгээдээр, хойт, умард талаар; *уулын хойгуур хөндлөн зам бий;* 2. ар этгээдээр, ар талаар, урд талаар биш; *би хойгуур чинь гаръя; морины олмыг хойгуур татах;* 3. дараа нь, хойно нь; *чамайг явсан хойгуур би танайд нэг удаа очив.*

ХОЙГУУРДАХ хэтэрхий хойгуур болох; *олом нь хойгуурдах.*

ХОЙГУУРДУУЛАХ хойгуурдахын үйлдүүлэх хэв.

ХОЙГУУРЛАХ хойгуур сууж хоцрох.

ХОЙД Монголын нэгэн овог.

ХОЙЛГО х у у ч и р с а н үхэгсдийг оршуулахад эд юм, мал адгуусыг дагалдуулан оршуулах ёс.

ХОЙЛГОЛОХ хойлго үйлдэх.

ХОЙЛОГ а м ь т а н биеийн урт нь жаран см. орчим, хүнд нь гурван кг. хиртэй, ургамал шавьж зэргийг идэж амьдардаг нэгэн зүйл зэрлэг тахиа.

ХОЙМОР гэрийн дотоод тулганаас хойшхи зай, хүндтэй суудал; *зочдыг хүндэтгэн хоймортоо суулгав.*

ХОЙНО 1. умар, хойт зүг; **өмнө хойно** х о р ш.; *хойноос ирсэн хонгон бөх...* о н ь с г о; 2. ар этгээд; *хойноос нь явах; хойноос нь дагах; гэрийн хойно гэдэн годон* о н ь с г о *хойноос ирээд хот манай, хотонд ирээд хонь манай* с э ц э н у г; 3. хожим, дараа, сүүлд; *би ахыг явсан хойно ирье; хойно юу болохыг бүү мэд; хойно хавсаргасан хүснэгт; урд ургасан чихнээс хойно ургасан эвэр* з ү й р; **ниргэсэн хойно хашгирах** (аливаа үйл явдал болж өнгөрсний эцэст санах, мэдэх, хэлэх, хийх); **өнгөрсөн хойно үглэх** (алив үйл явдал болж өн-

гөрсний эцэст нурших); **хүний хойно орох** (а. залхуурах, хойргоших; б. ажил явдалд үлдэж хоцрох); **өмнө хойно нь явах** (а. тус дэмжлэг үзүүлэх; б. бялдуучлан зулгуйдаж явах); 4. учир, газар, тул; *зузаан дээлтэй явна хойно халууцалгүй яах вэ!*

ХОЙНОГШ хойш, хойшид.

ХОЙНОГШИД хойногш, хойшид.

ХОЙНОДОХ хэтэрхий хойно болох.

ХОЙНОДУУЛАХ хойнодохын үйлдүүлэх хэв.

ХОЙРГО залхуу, удаан, хойш суумтгай; **залхуу хойргo** х о р ш..

ХОЙРГОДОХ дэндүү хойрго болох.

ХОЙРГОЛОХ хойрго зан гаргах, хойш суух.

ХОЙРГОХОН нилээд хойрго.

ХОЙРГОШИХ хойрго зан гаргах, залхуурах; *ийм явдалд хойргоших юу байх вэ!*

ХОЙРГОШУУЛАХ хойргошихын үйлдүүлэх хэв.

ХОЙТ 1. умар; *хойт зүг; хойт этгээд Хойт Мөсөн далай;* 2. ар талын; *эмээлийн хойт бүүрэг;* **хойт хөл** (дөрвөн хөлтний бөгсөн этгээдийн хөл); 3. дараагийн; *хойтын өдөр, хожмын маргааш;* **хойт жил** (ирэх жил): **хойтын хойт жил** (ирэх жилийн дараа жил); **хойт үе** (өсвөрийн залуу үе); **хойт эцэг** (төрсөн эцгийн дараагаар эцэг болсон хүн); **хойт эх** (төрсөн эхийн дараагаар эх болсон хүн); **хойт нь буух** (хүүхэд төрсний хойно ихэс дагалдаагаар гарах); **хойт мөр** ш а ш и н (үхсэний дараахь зам мөр); **хойт төрөл** ш а ш и н (үхсэний дараа төрөх төрөл); **хойт нас** ш а ш и н (үхсэний дараахи төрлийн амьдрал).

ХОЙТОН хойт жил, ирэх жил; *хойтонгоос хогод суна.*

ХОЙТХИ 1. хойнохи, умар зүгт бий; *хойтхи уулын цас цоохордов;* 2. ар дахь, арын, дараахь, *хойтхи хүн нь үрдхийнхаа шилийг хар!* 3. ихэс; **хойтхи нь буух** (ихэс цэглөх); **хойтхи нь түдэх** (ихэс түдэх).

ХОЙХНО 1. хойно; *энэ хойхно явж байна билээ;* 2. баахан хойно; *надаас хойхно ирсэн хүн.*

ХОЙХНУУР баахан хойгуур, арай хойгуур, хойт этгээд нь ойрхон; *тэр байшинд тон ойрхон, дөнгөж хойхнуур нь гарав.*

ХОЙЧ ирээдүй цаг, хожим; *хойчийг залгамжлах пионер багачууд;* **хойч өдөр** (хожим): **хойчийн хүн** (ирээдүй цагийн хүн).

ХОЙШ 1. дараа, хожим; **хойш тавих** (а. ажил явдлыг дараа, хожим болгох; б. юмыг нөөцлөн хадгалах); 2. сүүлд нь, дараа нь; *ажил тарснаас хойш; үүнээс хойш;* 3. учир, газар, тул; *та нар нэгэнт ирэхээс хойш;* **хойшоо** (а. хойт. умард зүг; *хойшоо яваад ирэв; хойшоо цас бага байна;* б. гэдрэгээ, ар тийш; *хойшоо суу! хойшоо, хойшоо, дайрна шүү!*); **хойшоо яарах** (буцах гэж яарах); **надаас хойш** (а. намайг нөхцөснөөс хойш; б. миний үеэс хойш; в. намайг эзгүй хооронд); **хойшоо явах** (а. хойт зүг очих; б. үл урагшлах болох); **хойшоо харах** (а. гэдрэгээ харах; б. өнгөрснийгөө харах); ☆ **хойш бай, хойшоо бай** (замаас зайлсхий, *чөлөө зай тавьж өг*); **хойш болох, хойшоо болох** (а. замаас зайлсхийж өгөх; б. хойшоо суух); **хойш нь хийх, хойшоо хийх** (а. ажил үйлийг нэгэнт гүйцэтгэн дуусгаж өнгөрүүлэх; б. эд хөрөнгийг хуримтлуулан нөөцөлж хадгалах); **хойш суух, хойшоо суух** (а. үйл ажлаас хойргошин бултарч хоцрох: б. ажил хөдөлмөрөөс чөлөөлөгдөн гэртээ орших болох).

ХОЙШГҮЙ 1. хожмыг боддоггүй, хойшлогогүй; *хойшгүй хүн;* 2. янар, дотор, наана; *аравдугаар сарын тавнаас хойшгүй.*

ХОЙШДОХ 1. хэтэрхий хойш болох; 2. хэтэрхий ар тийшээ болох, хэтэрхий гэдрэгээ болох; *ачаа хойшдох;* 3. хэтэрхий хожуу, хожим болох, хэтэрхий оройтох.

ХОЙШДУУЛАХ хойшдохын үйлдүүлэх хэв.

ХОЙШИЛДОХ 1. чөдрийн өмнөх этгээдийг хойш харуулан чөдөрлөх; *гууг хойшилдож саах;* 2. байн байн хойш болгох; *ажлаа битгий хойшилдоод бай!*

ХОЙШИЛДУУЛАХ хойшилдохын үйлдүүлэх хэв.

ХОЙШЛОГДОХ хойшлохын үйлдэгдэх хэв; *ажил хойшлогдож дараагийн ажилд муу нөлөө болох нь.*

ХОЙШЛОГОГҮЙ хожмыг огт боддоггүй, зөвхөн өнөө маргаашийг боддог; *чи яасан хойшлогогүй амьтан бэ!*

ХОЙШЛОГОТОЙ алс хэтийн бодлоготой, тусчхан зантай, хариу боддог.

ХОЙШЛОХ 1. хойт зүг явах, умар зүг очих; *бид хойшилж явна;* 2. гэдрэг ухрах, ар тий-

шээ явах; 3. дараа болох, хожим болох; *хурал хойшилжээ; бороотой учир явахаа хойшлов;* 4. удаашрах; *төлөвлөгөөт ажил хойшилсоор байв.*

ХОЙШЛОШГҮЙ хойш болгож огт болохгүй.

ХОЙШЛУУЛАХ 1. хойшлохын үйлдүүлэх хэв, хойш болгох; 2. умар зүгт явуулах, хойш нь явуулах; 3. гэдрэг нь болгох; 4. дараа, хожим, сүүлд болгох; 5. удаашруулах, цааргалах, хойш нь тавих; *энэ ажлыг ахин дахин хойшлуулсны хэрэггүй.*

ХОЙШЛУУЛШГҮЙ хойшлуулж огт болохгүй, хойш тавьж огт болохгүй, эрхгүй одоо шаардагдаж байгаа; *хойшлуулшгүй асуудал байв.*

ХОЙШТОХ улмаар хойш болох.

ХОЙШХИ 1. хойт зүг дахь; *хойшхи уулнууд цастай харагдана;* 2. хожмынх; *хойшхи ажлаа бодох хэрэгтэй байна.*

ХОЙШХОН 1 .нилээд хойш, баахан хойш; 2. дараахан, хожимхон, сүүлдхэн.

ХОЛ I ойрын эсрэг утга 1. алс, зайтай, бөглүү; **алс хол** х о р ш.; *хол шидэх; холоос харах; хол явах;* **ертөнцийн гурван хол** (өлссөн хүнд өдөр хол, эв муутад нөхөр хол, эцсэн моринд газар хол; 2. илүү, давуу; *хол зузаан; чамаас хол хурдан;* **түүнээс хол их** (давуу их); 3. ш и л ж с э н алсын ирээдүй, хожмын цаг; *холыг харах;* **холын бодлого** (ирээдүйн үйл явдлыг төлөвлөн бодох санаа).

ХОЛ II **хол хол хийх** сав доторхи шингэн юмны цалгихад гарах чимээ.

ХОЛБИ хүч нэмэгдүүлэх үг, булт, мулт; **холби үсрэх** (а. хажуу тийш гулган унах; *эмээл холби үсрэх;* б. булт үсрэн хажуу тийш зайлах).

ХОЛБИЛОХ холбируулах.

ХОЛБИРОХ 1. бултрах, юмнаас мултран унах; *хашаа унаж байгаад холбирох; морин дээрээс холбирох; эмээл холбирох;* 2. бултах; *холбирон зайлах.*

ХОЛБИРУУЛАХ холбирохын үйлдүүлэх хэв.

ХОЛБИЧИХ холбирох, холби үсрэх.

ХОЛБОГДОГЧ үйл ажилд татагдан оролцогч; *холбогдогч этгээд.*

ХОЛБОГДОЛ холбогдох үйлийн нэр; *холбогдол их; ач холбогдолтой.*

ХОЛБОГДОЛГҮЙ татагдан оролцох учиргүй; *холбогдолгүй хэрэг; холбогдолгүй болгох*

ХОЛБОГДОХ 1. холбохын үйлдэгдэх хэв; 2. ямар нэг юманд багтвал зохих, оролцвол зохих; *үүнтэй холбогдуулан зарлах нь; холбогдох зүйлүүд;* 3. хэрэгт орох, шийтгүүлэх; *гэмт хэрэгт холбогдох.*

ХОЛБОГДУУЛАХ холбогдохын үйлдүүлэх хэв.

ХОЛБОГО I загас агнах өөшийн дээд хэлхээнд тогтоосон усны дээгүүр хөвөх зүйл.

ХОЛБОГО II х у у ч и р с а н бөө, удганы хэц хэнгэргийн дотор талд хэлхэж дүүжилсэн ховхитой гонзгор төмрүүд; **холбого гүйлгэх** (холбогыг гүйлгэн хүний биед оруулж хорлох чадалтай гэж сүсэг бишрэлтэй хүмүүс эндүүрэн боддог байжээ).

ХОЛБОГОДОХ х у у ч и р с а н холбого гүйлгэх.

ХОЛБОЛДОХ холбохын үйлдэлдэх хэв, хэлхэлдэх сүлбээлдэх.

ХОЛБОЛДУУЛАХ холболдохын үйлдүүлэх хэв.

ХОЛБОО (Н) 1. юмыг хооронд нь холбосон зүйл; *суран холбоо; дээсэн холбоо; холбоотой тугал;* 2. харилцаа хэлхээ; **холбоо харилцаа** х о р ш.; *холбоо тасрах; холбоо зузаатгах; холбоо баригч;* **холбоо барих** (хэл мэдээ хооронд нь зөөх); 3. олон нийтийн байгууллага, эвлэл; *Дэлхийн зохиолчдын холбоо;* 4. нэг гүрний доторхи улсуудын нэгдэл; *холбооны бүгд найрамдах улс;* ☆ **чөдөр холбоо** (винтов бууны нэг зүйл хэрэгсэл).

ХОЛБООГҮЙ харилцаа, хэлхээ, барилдлагаа, сүлбээгүй.

ХОЛБООС холбосон юм, холбоо; *холбоосы нь сайн тохируул.*

ХОЛБООТ 1. холбоо бүхий, холбоотой; 2. холбооны улс бүхий; *зөвлөлт холбоот улс.*

ХОЛБООТОЙ 1. холбоо бүхий, харилцаатай, хэлхээтэй; 2. холбогдол учиртай; *чамтай холбоотой хэрэг.*

ХОЛБООТОН холбоо тогтоогсод; *хань холбоотон; холбоотон гүрнүүд.*

ХОЛБООЧ (ИН) холбоо баригч хүн.

ХОЛБОХ 1. хооронд нь салахгүй болгон уях, торгох; *олсоор холбох; хүзүүгээр нь холбосон хоёр үнээ байв;* 2. хэлхээ, харилцаатай болгох, найруулах, нийлүүлэх; **үсэг холбох**

(гийгүүлэгч эгшиг үсгүүдийг нийлүүлэн дуудах; *үсэг холбож уе тэмдэглэнэ; уе холбож үг тэмдэглэнэ; үг холбож утга тэмдэглэнэ*); **зуузай холбох** (эн зэрэгцэх); **хоёр сэтгэл холбох** (санал зохицож харилцан амраглах); **ураг холбох** (гэр бүл болох); **хушуу холбох** (шивэр авир хэлэлцэх, аминчлан ярилцах); **толгой холбох** (ярих, бичих, зохиохдоо мөр бүрийн эхний үсгүүдийг ижил болгох: б. эр эм болох; *тоонотой гэрт толгой холбох, тогоотой шөлөнд хушуу холбох* з ү й р).

ХОЛБУУЛАХ 1. холбохын үйлдүүлэх хэв; *утасны хороогоор холбуулах;* 2. холбогдох.

ХОЛГОХ нухагдан зулгарах, үрэгдэх, нухагдах, хэгзрэн шалбарах; *хөл холгох; холгож шалбалах.*

ХОЛГУУЛАХ холгохын үйлдүүлэх хэв.

ХОЛГҮЙ хол биш, ойр, алс биш, дөт; *нэгдлийн төвөөс холгүй газар орших үхрийн сүүрь дээр очив.* .

ХОЛДАХИН холынхон, хол байгсад, алст оршигчид.

ХОЛДАХЬ холхи, хол байгаа.

ХОЛДОХ 1. хэтэрхий хол болох; *бид холдоод очиж чадахгүй байна; энэ холдох уу? ойртох уу?* 2. салах, хагацах; *гэрээсээ холдож үзээгүй амьтан; эв нь холдох.*

ХОЛДУУЛАХ холдохын үйлдүүлэх хэв, хол болгох.

ХОЛИГДОХ холихын үйлдэгдэх хэв.

ХОЛИГЧ холих үйл гүйцэтгэгч; *ноос холигч; ном холигч.*

ХОЛИЛДМОЛ холилдсон, хутгалдсан, нийлсэн юм.

ХОЛИЛДОХ 1. хутгалдах, нийлэлдэх; *будаг холилдох; чихэр тос нь муу холилдсон байна; номууд цөм холилдсон байв;* 2. халдварт өвчтөн зэрэгтэй хутгалдан байх; *халдварт өвчтөнтэй холилдох.*

ХОЛИЛДУУЛАХ холилдохын үйлдүүлэх хэв.

ХОЛИЛТ холих үйлийн нэр.

ХОЛИЛЦОХ холихын үйлдэлцэх хэв.

ХОЛИМ у р г а м а л эрдэнэ шиштэй адил маягийн нэгэн зүйл тариа; ☆ **холим цас** (шамрага цас, ингэн туйлаадас).

ХОЛИМОГ дан биш, өөр юмтай нийлсэн, холилдсон нь; *адуу тэмээ холимог; сайн муу холимог;* **холимог хоол** (мах ногоо хольж хийсэн хоол).

ХОЛИМОЛ хольсон, холилдсон, холимог; *холимол тос; холимол тариа.*

ХОЛИО холих юм, хольц; *холио хийх; хоолны холио.*

ХОЛИОС хольсон юм.

ХОЛИХ 1. нийлүүлж хутгах; *хөзөр холих; алтанд зэс холих; тос холих;* **хольсон тос** (өрөм зөөхийг хайлж, тосы нь ялган аваад үлдсэн цөвд нь гурил, ээзгий, чихэр зэргийг хольж хийсэн цагаан идээ); 2. юмыг хооронд нь нийлүүлэн будлиантай болгох; *хооронд нь хольж үл болох бичгүүд; ярихдаа хольж солих.*

ХОЛОМДОХ загасыг шүүрхий шарах.

ХОЛСЛОГ а м ь т а н нэгэн зүйл шар шувуу, яваг шар шувуу ч гэнэ.

ХОЛТ хүч нэмэгдүүлэх үг, хэлт, элт, ховх; **холт татах** (татаж холтлох); **холт цохих** (цохиж холтлох).

ХОЛТЛОХ 1. холтроход хүрүүлэх, элтлэх, хэлтлэх; *холтос холтлох;* 2. дийлэх, хүч хүрэх; *би тэр ажлыг чинь холтлох байгаа.*

ХОЛТЛОХГҮЙ дийлэхгүй, хүч чадвар хүрэхгүй; *би яасан ч холтлохгүй хэрэг.*

ХОЛТЛУУЛАХ холтлохын үйлдүүлэх хэв.

ХОЛТОРХОЙ холторсон, холторч унасан газар, холторсон юм, хэлтэрхий.

ХОЛТОС (ОН) модны гадуур бүрхсэн зузаан давхгар хальс, зарим нутагт зодог ч гэдэг; *хар модны холтос; холтос түлэх;* ☆ **холтсон цэцэг** у р г а м а л (ихэнхдээ шар цэцэгтэй байдаг бөгөөд өвсөрхөг ургамал, шүүс нь гашуун бөгөөд хортой).

ХОЛТОСЛОХ модны холтсыг хуучиж авах.

ХОЛТОСРОХ холтос болох, холтос нь хөндийрөх.

ХОЛТОХ улам хол болох; *далбаат онгоц холт холтсоор бараа нь харагдахгүй болов.*

ХОЛТРОХ юмны хэлтрэх, холцрох, эмтрэх, ховхрох; *холтос холтрон унах.*

ХОЛТЧИХ 1. байн байн холтлох; 2. нэгэнт холтрон унах.

ХОЛТЧУУЛАХ холтчихын үйлдүүлэх хэв.

ХОЛХГОНОХ холхгор юмны үргэлжлэн хөдлөх.

ХОЛХГОР цөлхгөр, цондгор; *холхгор гэдэс.*

ХОЛХИ I холын, алсын; *холхи ууланд харагдах цас.*

ХОЛХИ II суларсан, сулдсан, сул болсон, уужим; *хадсан хадаас нь холхи болжээ.*

ХОЛХИВЧ алив машины бул эргэн холхих тулгуур; *холхивчийн завод;* **үрлэн холхивч** (алив машины эргэн холхих булын тулгуурт суулгасан үрэл).

ХОЛХИДОХ өлдөх, сулдах, чанга биш, сул байх, уужимдах; *холхидоод сугарч ойчих.*

ХОЛХИДУУЛАХ холхидохын үйлдүүлэх хэв, сулдуулах, уужимдуулах.

ХОЛХИНДОГ 1. гутлыг оймсгүй өмсөх; *холхиндог гутал; гутал холхиндог өмсөх;* 2. сул, холхи, уужим; *углуурга нь холхиндог болчихжээ.*

ХОЛХИУЛАХ холхихын үйлдүүлэх хэв.

ХОЛХИХ I. сулдах, өлдөх, ганхах, ганхаж хөдлөх, уужим болох; *углуурга нь сулдан холхих;* 2. сэлгүүцэн нааш цааш явах, тасралтгүй нааш цааш явах; *хүн үргэлж холхиж байдаг газар.*

ХОЛХОВЧ булын нүхэнд жийрэг болгож тавьсан цагариг төмөр; ☆ **холховч нум** (хичиргүй нум, сааль нум).

ХОЛХОЙЛГОХ холхойхын үйлдүүлэх хэв.

ХОЛХОЙХ холхгор болох; *гэдэс нь холхойж таргалах.*

ХОЛХОЛЗОХ холхгор юмны байн байн хөдлөх.

ХОЛХОЛЗУУЛАХ холхолзохын үйлдүүлэх хэв.

ХОЛХОН I баахан хол, нилээд хол.

ХОЛХОН II: **холхон холхон хийх** саван доторхи шингэн юмны зайлагдан дуугарах чимээ.

ХОЛХЬ холхи I.

ХОЛЦОРХОЙ холцорсон газар, холторхой.

ХОЛЦРОХ холтрох, халцрах.

ХОЛЦРУУ арьсны өнгө хөрсөнд осгоруутан тогтсон бэржгэр; *салхинд явсаар нүүр холцруу идэж орхив; холцруугны тос.*

ХОЛЦРУУТАХ холцруу идэх, холцруутай болох; *гар холцруутах.*

ХОЛЧ 1. хол явж чадагч, хол хурдлан чадагч; *холч морь;* **холч бялзуухай** (уран шувууны өөр нэр); 2. холын хараатай, хэтийн бодлоготой; *холч хүн.*

ХОЛЧИР холчиргон.

ХОЛЧИРГОН 1. урвах хөрвөх нь үлэмж, тогтворгүй ааль зантай; 2. бусдын үйл ажилд туслалцах санаатай ,хөнгөмсөг зантай.

ХОЛЧЛОХ 1. холыг сонгох, хол газар явах; 2. ш и л ж с э н гүнээ бодох; **холчлон** (а. хол, алс; *холчлон явах;* б. гүнээ; *холчлон бодох).*

ХОЛШООХ хол гэж тооцох, холд бэрхшээх.

ХОЛЬС 1. загасны элдсэн арьс; 2. загасны арьсыг элдэж хийсэн хувцас.

ХОЛЬЦ юманд холих холио; **хоолны хольц** (махнаас бусад гурил, ногоо зэрэг); **хольцтой алт** (өөр юм хольсон алт).

ХОЛЬЦОЛДОХ холилдох, хутгалдах; *өвчтөнтэй хольцолдох.*

ХОЛЬЦОЛДУУЛАХ хольцолдохын үйлдүүлэх хэв.

ХОЛЬЦОНГУЙ холилдмол, бусад юм нийлж хутгалдсан, хольцсон, холимог; *хольцонгуй өнгө; хольцонгуй зан ааш.*

ХОЛЬЦОО холио, холих юм, хольц.

ХОЛЬЦООГҮЙ дангаараа, цэврээрээ; *хольцоогүй алт; хольцоогүй мөн.*

ХОЛЬЦООТОЙ хольц бүхий юм; *хольцоотой мөнгө; хольцоотой эд.*

ХОЛЬЦОХ холилдох, хутгалдах.

ХОМ I 1. тэмээнд ачаа ачихад нуруу зоогий нь хамгаалахад бамбайлан нөмөргөх эсгий бамбай; *тэмээний хом; хомтой тэмээ;* **хомын бамбай** (тэмээ хомнох бамбай); **хомын шир дэг** (тэмээ хомнох ширдэг); 2. хөллөх малын хүзүүнд углаж, оосроор тэрэгний аралд холбох зүйл; *тэрэгний хом.*

ХОМ II тэмээний хоёр бөхний хажуу, зурааг дагасан хэсэг газрын зузаан өөх.

ХОМБОГО юм агуулахын гулд хөм ширээр хийсэн ачааны том сав; *хомбоготой ачаа.*

ХОМБОГОР 1. амсар этгээд нь доогуурхаас цухал сав; *хомбогор аяга; хомбогор тогоо;* 2. цомбогор; *хомбогор тууpай.*

ХОМБОЙЛГОХ хомбойхын үйлдүүлэх хэв.

ХОМБОЙХ хомбогор болох.

ХОМБОО хомбого сав; ☆ **хомбоо цай** (урт бөөрөнхий хэлбэртэй шахсан цай).

ХОМБОРОЙ гурав буюу дөрвөн шагаагаар ээлжлэн хаяж тоглох наадам, цөм ижил буюу цөм өөр буувал хожсонд тооцно; *хомборой хаях; хомборой буух.*

ХОМБОРОЙДОХ хомборой хаяж наадах.

ХОМБОРОЙЦОХ хомборой наадах.

ХОМГОЛЗОЛГО хомголзох үйлийн нэр.

ХОМГОЛЗОХ баахан хомхой зан байдал гаргах; *бусдын юманд хомголзох; хомголзох сэтгэлээ тэвч!*

ХОМГОЛЗУУЛАХ хомголзохын үйлдүүлэх хэв.

ХОМГОР сав суулганы ам амсар өмгөр бага; *хомгор амтай вааp.*

ХОМГОРДОХ дэндүү хомгор болох.

ХОМГОРДУУЛАХ хомгордохын үйлдүүлэх хэв.

ХОМГОРХОН баахан хомгор.

ХОМИС комисс.

ХОМИСЛОХ комисслох.

ХОМИСЛОГДОХ комиссоор орж гологдох, үл тэнцэх.

ХОМИСООР комиссар.

ХОМЛОХ хомнох, хомтой болж таргалах.

ХОМНОХ тэмээнд хомыг нөмөргөн тохируулж тогтоох; *тэмээ хомнох.*

ХОМНУУЛАХ 1. хомнохын үйлдүүлэх хэв; 2. хомногдох.

ХОМОЙЛГОХ хомойхын үйлдүүлэх хэв.

ХОМОЙХ хомгор болох, хомбойх.

ХОМООЛ адууны бөм бөм баас: **аргал хомоол** хор ш.; *адууны хомоол.*

ХОМОР ховор.

ХОМОРДОХ ховордох.

ХОМРОГО 1. ав хийхэд ан гөрөөсийг хорооолон авсан хүрээ; 2. шилжсэн уршиг, балаг; **хоморгонд орох** (а. авын хүрээнд гөрөөс орох; б. бусдын уршиг балагт чирэгдэх, холбогдох).

ХОМРОГОЛОХ тойрон томоолох, ээрэх, хүрээлэн хаших; *ав тавьж гөрөөсийг хомроголох.*

ХОМРОХ хомроголох.

ХОМС ховор, бага, элбэг биш; **хор хомс, ховор хомс** хор ш.; *хөрөнгөөр хомс ядуу айлууд байлаа.*

ХОМСДОХ хэтэрхий хомс болох.

ХОМСОДВОР улам хомостох нь.

ХОМСТГОХ хомстохын үйлдүүлэх хэв, хомс болгох; *орон тоо хомстгох.*

ХОМСТОХ улам хомс болох, багадах, цөөрөх.

ХОМСХОН баахан хомс, жижигхэн; *хомсхон биетэй хүүхэд;* **хомс хүртэх** (элбэг биш ногдох).

ХОМСШИГ нилээд хомс, бага, цөөн, элбэг биш.

ХОМХОЙ ховдог, шунаг, долгонцог; **хомхой ховдог** хор ш.; *хомхой зантай; хомхой сэтгэл;* ☆ **хомхой долоох** (хоол идээд амаа арчихгүй гадаа гарснаас болж уруул дээгүүр цөврүү үсрэх); **хомхой хуруу** (хоёрдугаар хуруу).

ХОМХОЙВТОР нилээд хомхой.

ХОМХОЙДОХ дэндүү хомхой болох.

ХОМХОЙЛОХ хомхой зан байдал гаргах, хомхойрох.

ХОМХОЙРОХ хомхой зан гаргах, ховдгорхох, хомхойлох; *олныг авах гээж хомхойрч явааd алдав.*

ХОМХОЙРУУЛАХ хомхойрохын үйлдүүлэх хэв.

ХОМХОЙРХОХ хомхойрох.

ХОМХРУУ I хомхруус.

ХОМХРУУ II хогжруу, хааж, гуужирхай; **хомхруу хогжрох** (хааж ховхрох).

ХОМХРУУС амуу будааны хальс, хэвэг; *шар будааны хомхруус.*

ХОМХРУУСЛАХ будаа тарианы хэвэг, хальсыг арилгаж цэвэрлэх; *будаагаа сайн хомхрууслаарай.*

ХОН I өгзөг.

ХОН II: **хон хон хийх** хонх мэтийн дуугарах чимээ гарах; *хонх хон хон хийж сонсдоно;* **хон өрөв** амьтан (өрвийн нэгэн зүйл шувуу); **хон хэрээ** амьтан (хэрээний нэгэн зүйл, бие том, өнгө нь гилтэгнэм хар, шөнө цугларан хоноглоно).

ХОНГИЛ 1. хад, модны давчуу хөндий зай; *хадны хонгил; модны хонгил;* 2. байшингийн доторхи нарийн гудам; *байшингийн хонгил;* 3. *чихний нүх.*

ХОНГИНОХ 1. хон хон хийж дуугарах; *хонх хонгинож байна;* 2. салхи шуурга тавьж аягүй болох; *хонгинотол салхилаад эвгүй өдөр байна;* 3. хүний дуу доройхон сонсдох; *дуу нь хонгиноод байх чинь яачих вэ.*

ХОНГИНУУЛАХ хонгинохын үйлдүүлэх хэв.

ХОНГИО 1. дотроо хөндийтэй зүйл; *хонгио мод; хонгио төмөр; сүмны хонгио;* 2. шилжсэн цуурайтсан, чанга; *хонгио дуутай.*

ХОНГО гуяны дунд чөмөгний арын зузаан махтай хэсэг газар; *хонгоны хар мах; хонго шаант; хонгоны шөрмөс татах;* ☆ **хонгыг ухах** хуучирсан (анз банзаар ихэд банздах).

ХОНГОР I адууны цайвар хул зүсэм; *ухаа хонгор морьтой, үлсын их жанжин* (Сүхбаатарын тухай дуунаас).

ХОНГОР II 1. цагаан, сайхан санаатай, муу бодол үл агуулах, харгүй; *хонгор санаатай амьтан;* 2. хайртай, янаг; *холын газраас зориод ирэв, хонгор Сүнжидмаагаа гэсээр ирэв* (ардын дуу); **хонгор зул** ургамал (дэлгэрэнгүй цэцгийн язгуурын олон наст, өвсөрхөг ургамал; нуга, ой, ойн захаар ургана, шир арьс будах шар будаг гаргаж авна, балтай).

ХОНГОРЦОГ I жимс, жимсгэнэ, буурцаг мэтийн залаалан сагсайж нэгэн салаанд шаваралдан ургасан нь; *усан үзмийн хонгорцог; лянхуа цэцгийн хонгорцог.*

ХОНГОРЦОГ II үсний бөөм бөөнөөр ширэлдэн хонх мэт унжин санжин явах хэсгүүд; *нохой сүүлээ, сүүл хонгорцгоо* з үйр.

ХОНГОРЦОГ III саравчинд шавхартсан мөс; ☆ **хонгорцог цэцэг** ургамал (хулс модтой адилхан иштэй, үр нь хонгорцог адил нэгэн зүйл цэцэг); **хонгорцогт мод** ургамал (хайлаастай адилхан, үр нь хонгорцоглон ургадаг мод, цэцэг нь шар, будахад хэрэглэнэ).

ХОНГОРЦОГЛОХ 1. хонгорцог хонгорцгоор сагсайн унжиж ургах; *жимс хонгорцоглон ургах;* 2. хувцас элэгдэн урагдаж унжин санжин ноорох; *дээлийн хормой бүр ч хонгорцог болж гүйцэв.*

ХОНГОРЦОГЛУУЛАХ хонгорцоглохын үйлдүүлэх хэв.

ХОНГОРЦОГТОХ 1. хонгорцог бий болох; 2. цас хайлж шавхартсан нь үлэмж болж хэсэг хэсэг болон тогтох.

ХОНД I улбар улаан буюу улаан ухаа будаг; *тугалган хонд; төмрийн хонд.*

ХОНД II хавар намрын баахан хүйтэн цагт бог малын зэргийг арчлан буудаллах бяцхан бууц; **хонд бууц** хор ш.; **хонд шаант** (мал гөрөөсний шаант чөмөг хонго махны хамт, хонго шаант ч гэдэг).

ХОНДДОХ хондоор будах.

ХОНДДУУЛАХ хонддохын үйлдүүлэх хэв.

ХОНДЛОЙ амьтны биеийн нурууны шувтрах ар хэсэг; *хондлой дээр нь унах; морины хондлой.*

ХОНДЛОЙДОХ 1. хондлойгоос барих; 2. морь малд ачсан ачаа хэтэрхий хойшдож тохиромжгүй болох.

ХОНДЛОХ хонд газар бууж нутаглах.

ХОНДОГО I шошго, тэмдэгт пайз; **хондого шошго** хор ш.; *хурдны морины хондого; эмийн хондого.*

ХОНДОГО II морины уяа хэц.

ХОНДОГО III хуучирсан зуун тавин эр цэрэг үл хүрэх хагас сум.

ХОНДРОХ хонд мэт болох.

ХОНЖВОР хонжиж авах юм; **ашиг хонжвор** хор ш.; *хонжвор олох; хонжворт сугалаа; хонжворт зээллэг.*

ХОНЖИГДОХ 1. хонжихын үйлдэгдэх хэв; 2. хожигдох.

ХОНЖИГЧ 1. хонжооч, хонжиж бий тал, хожигч; 2. хонжихыг эрмэлзэгч.

ХОНЖИЛ хонжих үйлийн нэр, хожил, хонжвор.

ХОНЖИХ 1. хожих, юмнаас үнэ нэмж завшин ашиглах; *худалдаа хийж завсраас нь ашиг хонжих;* 2. наадам тоглоомд тоглож давах; *шатар тавьж хонжих;* 3. ш и л ж с э н давуутай талыг олж чадах; *хүйтэнд гэртээ байсан нь хонжино.*

ХОНЖЛОГО хонжсон ашиг нь, хонжил, хожил.

ХОНЖОО хожоо, хонжвор, хонжиж олсон ашиг: **ашиг хонжоо** х о р ш.; *хонжоотой наймаа болжээ.*

ХОНЖООЧ хонждог, хонжиж амтшисан, хожооч; *хонжоочийн хойгуур хоёр хүн сундлана.*

ХОНЖУУЛАХ 1. хонжихын үйлдүүлэх хэв; 2. хонжигдох.

ХОНИМЖ а м ь т а н янз байдал ирвэстэй адил болоод сүүл маш урт, хэвтэхдээ сүүлээ ороож хэвтдэг, сурхий орхирон дуугардаг нэгэн зүйл амьтан.

ХОНОГ I 1. өдөр шөнийн хорин дөрвөн цаг, нэг өдөр нэг шөнө нийлж хорин дөрвөн цаг болох хугацаа; *гуч хоногтой сар; долоо хоног;* 2. шөнө, шөнө хонох нь; **шөнийн бор хоногт** (өдрийг арайхийн өнгөрөөж шөнө нь унтаж амрах болоход); **хоног тохиолдох газар** (хонох газар); **зуур хоногийн газар** (замдаа нэг хонох газар); **хоног өнгөрүүлэх** (айл хэсүүчлэн хонох).

ХОНОГ II: **хоног будаа** шаравтар өнгөтэй нэгэн зүйл тариа; **хоног амуу** у р г а м а л (үр мөхлөг нь улаан хоногтой адил бөгөөд өнгө шар, чанахад өсч арвидах нь үлэмж, хүн идвэл болно, мал тэжээхэд сайн, иш өвсийг морь малд хэрэглэдэг нэгэн зүйл тариа); **улаан хоног** у р г а м а л (хоног амуутай адил болоод хэвэг улаан нэгэн зүйл тариа); **усан хоног** у р г а м а л (янз монгол амуутай адилхан нэгэн зүйл тариа).

ХОНОГ III зарим нэгэн юманд ямар нэгэн зүйлийг тогтоох тээглүүр хэрчлээс; *хоног гаргах.*

ХОНОГЛОХ 1. хонох; *хоноглох газар;* 2. *тахианы хонуурта орох;* 3. ш и л ж с э н ямар нэг юманд хүсэн санаашрах болох; *сэтгэл хоноглох.*

ХОНОГЛУУЛАХ хоноглохын үйлдүүлэх хэв.

ХОНОГШИХ цээжинд тогтох, дотроос гарахгүй болох, ухаанд тогтох; *цээжинд хоногших; сэтгэлд хоногших; чихэнд машины дуу хоногших.*

ХОНОГШУУЛАХ хоногшихын үйлдүүлэх хэв.

ХОНОХ шөнийг өнгөрөөх, нөхцөөх; *нэг хонох; хээр хонох; хонон өнжин явах; зуур хонох; айлд хонох.*

ХОНОЦ гаднаас ирж хоносон хүн; *хөл ихтэй, хоноц олонтой байжээ;* 2. хоноглох газар; *хоноц олдохгүй арга барагдаж явна.*

ХОНСОЛ консул.

ХОНТОЛ эчнээгээр суутган авсан ашиг.

ХОНТООР контор, албан үүрэг гүйцэтгэх газар.

ХОНТООРЛОХ конторлох, хонтоортоо сууж ажиллах.

ХОНТОХ нууц хонжих, далдуур сэмхэн хонжих, юмнаас эчнээгээр ашиг болгон суутгаж авах.

ХОНУУЛАХ хонохын үйлдүүлэх хэв.

ХОНУУР тахианы байрлах, хоноглох байр; *тахианы хонуур.*

ХОНХ I дохио тэмдэг өгөх зэрэгт хэрэглэх, голдоо дэлдэх хэлтэй төмөрлөг зүйл; *завсарлагын хонх дуугарах; дугуйны хонх; хонх цохих; хонхон дуутай нохой нэгэн жил;* **чихэнд хонх уях** (ямар нэгэн юмны тухай үргэлжлэн үглэж цөхөөх): **хонх цэцэг** у р г а м а л (нэг салаанд хэд хэдэн хүйстэй, анхилсан сайхан үнэртэй, хонхон хэлбэртэй, цагаан цэцэгтэй ургамал); **төмсний хонх** (зэрлэг төмсний цэцэг).

ХОНХ II хүч нэмэгдүүлэх үг; **хонх цохих** (цохин хонхойлгох).

ХОНХВОЙ: **хонхвой цэцэг** у р г а м а л таван зүйлийн өнгө бүрэн бүрдсэн нэгэн зүйл цэцэг.

ХОНХГОР хонхор, ёнхор.

ХОНХДОХ хонх дуугаргах, хонх цохих.

ХОНХДУУЛАХ хонхдохын үйлдүүлэх хэв.

ХОНХИГОНОХ хүний базаахгүй зан царай гарган хөдлөх, аашлах.

ХОНХИГОР эцэнхий, туранхай, цонхигор царайтай; *царай нь хонхигор л байна, бие нь сайжирч чадаагүй бололтой.*

ХОНХИЙХ хонхигор болох, цонхийх; *царай нь их л хонхийсон харагдана билээ.*

ХОНХИЛДОГ гутал оймсны зэрэг юмны уужимхан холхий нь; *хонхилдог гутал.*

ХОНХИЛЗОХ хүний ёхиволзох, муухай ааш гаргах, цонхилзох.

ХОНХИЛУУР нумны хичрийн угийн ар талын хоёр этгээдэд говил гаргасан нь.

ХОНХИР цонхир, хонхигор.

ХОНХЛОХ хонх мэт цэцэгт ургамлын цэцэг ургаж биелэх; *ярагуйн цэцэг хонхолж байна.*

ХОНХЛИГ: **хонхлиг цэцэг** у р г а м а л өлгөсөн хонхны хэлбэртэй нэгэн зүйл цэцэг.

ХОНХОЙЛГОХ хонхойход хүргүүлэх, хонхор болгох.

ХОНХОЙЛОХ хонхор болгох, хотгор болгох хонхор гаргах; *хөлийн өгсийгөөр шороо хонхойлж зогсов.*

ХОНХОЙХ 1. хонхор болох; **хонхойх цонхойх** х о р ш.; *энэ хүүхдийн хацар хонхойх юм; дарахад хонхойх;* 2. ш и л ж с э н хорох, хорогдох, бага болох, хотойх; *хонхойхгүй баян сүрэг малтай;* **хонхойтол хорох** (үлэмжхэн хорох).

ХОНХОЛЗОХ зөөлөн юмны хонхос хонхос хийх; *дарахад хонхолзох;* **гэдэс хонхолзох** (өлсөх).

ХОНХОР 1. хотгор, гүнзгий тийшээ болсон, юман дээрх хотгор; **хонхор цонхор** х о р ш.; *алганы хонхор; тахимын хонхор; суганы хонхор; хонхор газар; хонхор дотор ороод харагдахгүй болжээ;* 2. нам дор, далайн түвшнээс хоёр зуун метрээс өндөр биш газар; *хонхор газар орших айл тосгон.*

ХОНХОРДОХ дэндүү хонхор болох.

ХОНХОРЛОХ хонхор болгох.

ХОНХОРХОЙ хонхор болсон нь, хонхор; *хацар дээрх хонхорхой; хонхорхой лааз.*

ХОНХОСХИЙХ хонхор болон алдах, гэнт хонхойн завдах; *гишгэхэд хонхосхийх.*

ХОНХТ: **хонхт алаг** а м ь т а н нисэхдээ дуугардаг нэг зүйл нугас, загас барьж иднэ, мах нь муу; **хонхт уран** а м ь т а н (өнгө алаг, дуу нь хараацайн дуутай адил нэгэн зүйл бялзуухай).

ХОНХТОХ бороо ороход усны дусал цөврүүтэх.

ХОНХТУУЛАХ хонхтохын үйлдүүлэх хэв.

ХОНШООР 1. амьтны хамрын шонтгор үзүүр; **хамар хоншоор** х о р ш.; *гахайн хоншоор;* 2. гутлын урд талын үзүүр орчин, гутлын хамар, гутлын хушуу ч гэдэг; *гутлын хоншоор.*

ХОНШООРДОХ хоншоороос барих.

ХОНШООРЛОХ хоншоор гаргах, хоншоор хийх; *гутал хоншоорлох.*

ХОНЬ (ХОНИН) 1. гэрийн тэжээвэр, сүүн тэжээлт хэвдэг адгуус, Монголын таван хушуу малын нэг, төрөлх номхон, сүү ба мах нь сайн, үс буржгар зөөлөн, ноос нь арвин, эсгий болоод нэхмэл хийхэд маш зохимжтой; *хонь мал; хонин сүрэг; хонины хашаа; хонины мах;* **хонь гаргах, хонь алах** (хонь нядлах); **хонь хяргах** (хонины үсийг хайчаар хяргах); 2. сарны зурхайн арван хоёр эрхтний найм дахь нь;**хонин жил** (сарны зурхайн арван хоёр эрхтний доторхи хонь эзэлсэн жил); 3. хүүхэд багачуудын хумсны толионд голдуу үзэгдэх өчүүхэн цагаан цэг; *арван хурууныхаа хумс бүрд хоньтой;* **хонин арц** у р г а м а л (арцны нэг зүйл, өргөслөг биш, үнэр сайтай); **хонин шарилж** у р г а м а л (хонхор тойром, төхөм газар ургадаг нэгэн зүйл шарилж, өндөр нь дэлэм хүртэл, салаа гишүү нь морин шарилжны адил, өнгө цайвар ногоон, буурцаг хар будааны хиртэй, аль ч цагт тэмээ бог малд зохимжтой тэжээл болно); **хонин сойх** у р г а м а л (нэгэн зүйл зэрлэг ургамал, болгож идвэл болно, исгэлэн ус хийнэ); **хонины нүдэн цэцэг** у р г а м а л (хэлбэр улаан баян цэцэгтэй адил, зэрэг зэрэг давхацсан хэлтэс цэцэгтэй, цэс цэцгийн адил өнгөтэй нэгэн зүйл цэцэг); **хонин мэхээр** у р г а м а л (өндөр нь гучин см. орчим, иш шулуун, уртавтар навчтай, навчны дээд тал гялгар, доод тал нь цайвар ногоон нэг зүйл ургамал); **хонин бургас** у р г а м а л (хангай бүсийн ширэнгэнд ургадаг нэгэн зүйл бургас, мал үл иднэ); **хонин зангуу** у р г а м а л (жалга, зөөлөн хөрстэй газар ургадаг ургамал, өндөр нь тохой шахам, иш гишүү олон салаа гарч сүлжин буталж

ургана, навч иш үслэг бөгөөд өнгө цайвар ногоон, мал төдий л идэхгүй); **хонин гөрөөс** (аргаль угалз); **хонин өтөг** а м ь т а н (өмнөх хөл маш богино, бяцхан биетэй өтөг); **хонин хараацай** а м ь т а н (голын эрэг орчноор үүр хийж орших нэг зүйл хараацай); **хонин хяргуй** а м ь т а н (морин хяргуйн эрэгчин, бие жижигхэн); **хонин цууцль** а м ь т а н (хушуу нарийн, бие бяцхан, шөнө дуугардаг нэгэн зүйл шувуу); **хонин шатар** (нэгэн зүйл тоглоом, цагаан хар хорин дөрвөн ширхэг мигмангаар хоёр хүн тусгай хөлгөн дээр хаалцан наадна); **хонин хашаа** (намхан хашаа).

ХОНЬЖИХ хоньтой болох, хонь олон болох.

ХОНЬЖУУЛАХ хоньжихын үйлдүүлэх хэв.

ХОНЬЧ хонь маллагч.

ХОНЬЧИН хонь хариулах хүн; *нэгдлийн хоньчин залуу; хоньчин хүнд хоол хэрэгтэй, хожгор хүнд малгай хэрэгтэй* з ү й р.

ХООВГОНОХ хоовгор юмны үргэлжлэн хөдлөх.

ХООВГОР шомбогор, ёмбогор, гонзгордуу хэлбэртэй; *хоовгор ёмбон толгойтой.*

ХООВОЙЛГОХ хоовойхын үйлдүүлэх хэв.

ХООВОЙХ хоовгор болох.

ХООВОЛЗОХ хоовгор юмны байн байн хөдлөх.

ХООВОН 1. нүүрс ноцоож хөлчөөх сав; *ширмэн хоовон;* **цахилгаан хоовон** (хоол унд хийхэд зориулсан цахилгаан халаагуур хэрэгсэл); 2. ш о о д с о н шомбогор, гонзгор, ёмбогор; *хоовон толгой.*

ХООЛ идэх тэжээлийн зүйл; *үдийн хоол; махтай хоол; будаатай хоол; цагаан хоол; хоол тэжээл; хоол хүнс;* **хоолны холио** (хоолонд хийх махнаас бусад гурил, ногоо, будаа зэрэг зүйлс); **хоолны худалдаа** (хоол хийж худалдах газар); **хоол тавих** (хоолноос үлдээж хадгалах); **хоолонд орох** (хоол иддэг болох, өвчтөн буюу нялх хүүхэд хоол иддэг болох); **хоолонд муу** (хоол ихээхэн идэж чадахгүй); **хоолонд сайн** (хоол ихээхэн иддэг); **хоол муутай** (а. шим, тэжээл муутай: б. хоол олигтой идээгүй; в. хоолоор дутмаг); **хоол сайтай** (а. шим тэжээл сайтай; б. хоол сайн идсэн; в. идэш тэжээл элбэг); **хоол хийх** (а. хоол боловсруулан үйлдэх б. ялихгүй юм идээд хоолшиж чадах; *би юухнаар ч хоол хийж чадна);* **хоолноос гарах** (дур больж үл идэх); **цагаан хоол** (а. мах оролцоогүй хоол; б. биеийн эрүүл мэндэд тохируулан өгөх сувиллын хоол: *цагаан хоолны гуанзанд орох);* **хоол боловсруулах эрхтэн** (амны хөндий, ходоод, арван хоёр хуруу гэдэс сөс зэрэт эрхтнүүд); **хоолны сав** ш о о д с о н (идэхээс өөр юм хийдэггүй, хийж чаддаг юм байхгүй); **хоолны эзэн** ё г т (хүүхэн хэл).

ХООЛБОЙ хонь ямаар саах, холбохоор барихын тул дуудах аялга, хоолгой; *хоолбой, хоолбой!*

ХООЛГОЙ хоолбой.

ХООЛЗУУР төвөн.

ХООЛЛОХ 1. хоол идэх; 2. хоол идүүлэх; *хүүхэд хооллох.*

ХООЛЛУУЛАХ хооллохын үйлдүүлэх хэв.

ХООЛОВЧ 1. хувцасны зааманд хадсан, хүзүү халхлах өмсгөл; 2. хоол идсэний дараа амны тос арчих жижиг алчуур.

ХООЛОЙ 1. хүзүүний өвөр хэсэг, юм залгих мөр, амьсгалын мөрийн зарим хэсэг багтана; **улаан хоолой** (юм залгих мөр); **цагаан хоолой** (амьсгалын мөр); **амьсгалын хоолой** (цагаан хоолой); **буруу хоолой, хуурай хоолой** (цагаан хоолой, мөгөөрсөн хоолой); **хоолой сөөх** (хүн амьтны цагаан хоолойн мөгөөрс гэмтэж дуу нь бууран гутах): **хоолой сөөнгө** (хоолойн дуу бууран сөөсөн); **хоолойн зүү; хоолойн чимэг** (дээл хувцасны энгэрт хатгах гоёлын чимэг); **хоолойн шилбэ** (хоолойн товчийг товчлон тогтоох гогцоо); **хоолойн товч** (дээл, цамц зэрэг хувцасны заамд хадсан товч); **хоолой боох** (цагаан мөгөөрсний дотор талд гэмтэл учран амьсгал боох өвчин); 2. дуулах өнгө, дуу; **бүдүүн хоолой, умзад хоолой** (өтгөн дуугаар дуугарах); **аргил хоолой** (эрэгтэй хүний бүдүүн дуу); **тунгалаг хоолой** (эмэгтэй хүний нарийн дуу); **шингэн хоолой** (нарийн дуу); **өтгөн хоолой** (аргил бүдүүн дуу); **хоолой сайтай** (дуулахад дуу яруу сайхан); **хоолой муутай** (дуулахдаа дуу яруу биш, муу дорой); **хоолой хохтнох** (хоолой хохон хохон дуугарах); **хоолой засах** (бага зэрэг ханиах мэт дуу гаргах); **хоолой зангирах** (сэтгэл үлэмж түгшин хөдөлж, үг хэлж чадахгүй болох); 3. хоёр уулын хоорондох өргөн хөндий; *халцурсан өвстэй хоолойг оглон гарав;* 4. хоёр нуурыг холбосон горхи сувиг; *сувag хоолой татах;* 5. юмыг дамжуулан илгээх гуурс; *муу усны хоолой; төмөр хоолой; цэвэр усны хоолой.*

ХООЛОЙВЧ хүүхдийн хүзүүнд зүүж хувцсыг хамгаалах зүйл.

ХООЛОЙТОЙ 1. хоолой бүхий; 2. дуулахдаа яруу сайхан дуутай, хоолой сайтай; *сайхан хоолойтой хүүхэн.*

ХООЛОЙЧИН малын хоолойг огтлон алах яргачин.

ХООЛОНЦОР идэхдээ ховдог.

ХООЛТОЙ 1. хоол бүхий; *хоолтой хонох;* 2. хоол элбэгтэй, хөрөнгө чинээлэг; *хоолтой айл;* 3. шим тэжээл сайн, өег.

ХООЛЧ хоол хийхдээ чадамгай хүн.

ХООЛШИХ идсэн юм хоол болж биед зохимжтой шингэх.

ХООРМОГ сүүгээр шингэлж исгэсэн тараг.

ХООРОНД 1. дунд, завсар; *хоёр уулын хооронд; хоёр гэрийн хооронд; хоорондын зай; хооронд нь холбох; хоёр хүний хооронд; хоорондоо хэлэлцэн тохирох;* **хоорондын хэрэг** (хоёр хүний хувийн хэрэг); 2. зуур, завсар; *яваад ирэхийн хооронд; түүнийг байхгүй хооронд; хоорондын хэлэлцээ; хоорондын найрамдал;* ☆ **хоёрын хооронд** (дэмий, саармаг, аль нь ч биш; *олигтойхон биш бол хоёрын хооронд юм хэрэггүй).*

ХООРОНДОХЬ хооронд байгаа юм, дунд байгаа юм, завсрын; *хоёр улсын хоорондохь.*

ХООСДОХ хоосны учир зохисгүй болох.

ХООСДУУЛАХ хоосдохын үйлдүүлэх хэв.

ХООСЛОХ 1. хоосон болгох, ядуу зүдүү болгох; *хөрөнгийг хоослох;* 2. дотор нь юмгүй болгох; *сав хоослох.*

ХООСЛУУЛАХ 1. хоослохын үйлдүүлэх хэв; 2. хоослогдох.

ХООСОВТОР нилээд хоосон ядуу.

ХООСОН 1. үгээгүү; **ядуу хоосон үгээгүү хоосон** х о р ш.; *хоосон хүн; хоосон хүний зовлон хорь гуч;* **хоосон нойтон** (ядуу ядмаг); **хоосны туйл** (ядуугийн туйл); 2. дотроо юмгүй, хөндий, сул; *хоосон өрөө; хоосон шил; хоосон авдар;* **гар хоосон** (гартаа юмгүй); **хоосон хонох** (хоолгүй хонох); **хоосон цай уух** (идэх юмгүй дан цай уух); **хоосон буу** (сумгүй буу; *хоосон буунаас хорин хүн айх* з ү й р); **хоосон огторгуй** (хөндий огторгуй); **хоосны агаар** (хөндий огторгуй); **хоосны зүг** (дээд зүг); **хоосон чанар** (шашны ёсонд: юм бүхэн мөнх биш чанартай гэдэг номлол); **ертөнцийн гурван хоосон** барин тавин байвч зүүд хоосон, барайж тойж байвч зэрэглээ хоосон, бархирч чаралж байвч цуурай хоосон); 3. ш и л ж с э н дэмий, ончтой биш, үл биелэгдэх: *хоосон тооны хойноос хөөцөлдөх;* **хоосон яриа** (дэмий яриа); **хоосон нэр** (нэрээс цааш юмгүй); **хоосон ам** (амнаас цааш үр бүтээлгүй); **хоосон үг** (үр ашиггүй үг); **хоосон санаа** (хий хүсэл).

ХООСООР дэмий, талаар; *хоосоор горьдох; зүтгэсэн зүтгэл нь хоосоор өнгөрчээ.*

ХООСРОХ 1. хоосон болох, ядуу болох; *хоосорч гүйцэх;* 2. дотроо юмгүй болох; *хувин хоосрохыг хүлээх.*

ХООСРУУЛАХ хоосрохын үйлдүүлэх хэв, хоослох.

ХООХОЙ арч, арчаа; *аминдаа хоохойтой.*

ХООХОЙЛОХ аргалах, арчлах; *амиа хоохойлох.*

ХООХОЙЛУУЛАХ 1. хоохойлохын үйлдүүлэх хэв; 2. хоохойлогдох.

ХОР I 1. бие махбодыг хордуулж гэмтээх бодис; *хор идэх; могойн хор;* **хорны ерөндөг** (хоргүй болгох зүйл); 2. ш и л ж с э н гэм, хөнөөл, аюул зовлон; **хор хөнөөл** х о р ш.; *гэм хор хүргэх; хор олох; хор хөнөөл учруулах;* **хор хийх** (а. бусдад хор хүргэх; б. хорыг найруулах): **хор хүргэх** (бусдад хор хийж хөнөөх); ☆ **хор өвс** у р г а м а л (хээрийн бүс, говирхуу газар ургадаг, ягаан шар, улбар цэцэгтэй, олон наст ургамал, төрөл зүйл олон, зарим нь хортой).

ХОР II атаархан тэсч ядан хорсох сэтгэл; **хор шар** х о р ш.; *хор нь хөдлөн гар нь чичирч байв; эр барагдавч, хор барагдаагүй;* **хор хөдлөх** (атаархан тэчьядах, тэсч ядах); **хоры нь маажих, хоры нь малтах** (тэчьядам үгээр басамжлан эгдүүг хүргэх, зэвүүр үүлэх; *хоры нь малтсаар байж, барилдуулж орхив);* **хорондоо** (санасандаа хүрэн, хэгжүүрхсэн санаандаа; *би хорондоо яваагүй);* **хор ихтэй хүн** (атаархал сэтгэл ихтэй хүн); **хор нь буцлах** (атаархал сэтгэл нь ихэд хөдлөх).

ХОР IH: **хор хор хийх** (хоржигнох дуу чимээ гарах; *горхины ус хор хор урсах; хонх хор хор дуугарах; хоолой нь хор хор дуугарах.*

ХОР IV: **хор хомс** барагдах хорогдох нь түргэн хялбар, арви муутай.

ХОРВОЙХ хоровгор болох, атирах, хорчийх.

ХОРВОС хоёр настай зэрлэг гахай.

ХОРГО юм хум агуулах сав; *хувцас хунар хийх хорго; шувуу хулгана зэрэг амьтныг хорих хорго; зул гэрлийг нөмөрлөх хорго;* **хоргон бишгүүр** (бүдүүн охор хонгионд таван нүх гарган хийсэн үлээж дуугаргадаг хөгжмийн зэвсэг).

ХОРГОДОО хоргодох зантай; *хоргодоо хүрэн мориороо холыг зорин явав.*

ХОРГОДОХ 1. хүн амьтны санал хүсэл, нэгэн юманд чиглэн түүндээ татагдан байх, хоргоцох; *айн бэрхшээж хоргодох; ашиг тусыг эрмэлзэж хоргодох; санаа хурьцаж хоргодох; морь хоргодох;* 2. биеэ арчлах хамгаалахын эрхээр ямар нэгэн юманд багтаж орших; *гадаад улсад хоргодох; айлд хоргодох.*

ХОРГОДУУЛАХ хоргодохын үйлдүүлэх хэв.

ХОРГОЙ нэгэн зүйлийн бараа, нолом ч гэнэ; *хятад хоргой; төвд хоргой; орос хоргой; дээлийн эмжээрийн хоргой.*

ХОРГОЛ жижиг бөөрөнхий хэлбэртэй баас; *хонины хоргол; туулайн хоргол;* ☆ **хорголоо тоолох** (маш нарийн харамч зан гаргах).

ХОРГОЛДОХ хэтэрхий хоргол болох.

ХОРГОЛЖ (ИН) тугалга; *хорголжин сум; хорголжин хэвлэл.*

ХОРГОЛЖИТ хорголж бүхий, хорголжтой, тугалгат.

ХОРГОЛЗОХ 1. юмны нэгэн тийш зорьж чиглэхгүй эрэгцэх, үймцэх; *айж бахардан хэрхэх аргаа олохгүй дэмий тэвдэн хорголзох; салхи шуурганы дараа дараагаар зүг зүгээс сэлгэцэн үймцэж хорголзох;* 2. хоргодох.

ХОРГОМЧ горьдуулан хуурагч.

ХОРГОМЧЛОГДОХ хоргомчлохын үйлдэгдэх хэв.

ХОРГОМЧЛООЧ хоргомчлох ааш зантай.

ХОРГОМЧЛОХ хүн амьтанд юм хум өгөх буюу ээрсэн хүссэн зүйлийг бүтээх байдал гаргах мэтээр горьдуулаад түүнийгээ гүйцэтгэхгүй хууралхилах.

ХОРГОМЧЛУУЛАХ 1. хоргомчлохын үйлдүүлэх хэв; 2. хоргомчлогдох.

ХОРГООГДОХ хоргоохын үйлдэгдэх хэв.

ХОРГООЛГОХ 1. хоргоохын үйлдүүлэх хэв; 2. хоргоогдох.

ХОРГООХ 1. байн байн ээрэх, эрэгцүүлэх; *гөрвөс хоргоох;* 2. шалж шавдах; *манай дүү надаас юм авах гэж тон их хоргоов.*

ХОРГОЦОХ хоргодох, хургах.

ХОРГҮЙ 1. гэм хөнөөлгүй; *хоргүй могой; хоргүй амьтан;* 2. атаа сэтгэлгүй; *хор харгүй; хор шаргүй.*

ХОРДЛОГО хордох үйлийн нэр; *хоолны хордлого болжээ.*

ХОРДОХ I хүн амьтанд ямар нэгэн хор гусч бие махбод нь гэмтэх.

ХОРДОХ II хор шар хөдлөх.

ХОРДОХ III атаархах.

ХОРДУУЛАХ хордохын үйлдүүлэх хэв.

ХОРЖИГНОХ юмны харшиж хавиралдах, хор хор дуугарах чимээ гарах; *ус хоржигнох; хоолой хоржигнох.*

ХОРЖИГНУУЛАХ хоржигнохын үйлдүүлэх хэв.

ХОРЗ шимийн архиар нэрсэн арзыг бас нэрж гарсан маш хатан архи.

ХОРЗЛОХ арзыг нэрж хорз болгох; *хорзолж нэрэх.*

ХОРЗЛУУЛАХ хорзлохын үйлдүүлэх хэв.

ХОРИГ 1. хориул, хорио; *саад хориг; хориг тавих;* 2. хүний муу буруу, өө сэв буюу бусдад муу санасан атаг; *муугий нь гаргаж, хоригий нь уудлах;* 3. хүн амьтны эрх эмзэг газар; *толгойдоо хориг морь.*

ХОРИГДОЛ ял шийтгэгдэж хорионд байгаа хүн.

ХОРИГДОХ 1. хорихын үйлдэгдэх хэв; *гянданд хоригдох;* 2. боогдох саатах; *бороонд хоригдох; усанд хоригдох.*

ХОРИГЛОЛ хориглох үйлийн нэр; 1. ятгалга, сургамж; 2. бэхлэлт; *танк эсэргүүцэх хориглол.*

ХОРИГЛОЛТ хориглол болгосон юм, бэхлэлт.

ХОРИГЛОХ 1. буруугаар явахыг зогсоож ятгах, сургах; *хориглон хэлэх;* 2. хорих, хориг болгох; *хориглон байлдах; ууланд хориглох.*

ХОРИГЛУУЛАХ 1. хориглохын үйлдүүлэх хэв; 2. хориглогдох.

ХОРИО 1. цээртэй зүйл, үл болох зүйл; *хорио тэмдэг; эамын хорио;* 2. ятгалга, сургамж; **хорионд орох** (ятгалгыг дагах); 3. гяндан; *хорионд хоригдох.*

ХОРИОГҮЙ хориг, цээргүй; *хориогүй явдал; хориогүй зам.*

ХОРИОД 1. хорь орчим, хорь хир; *хориод настай; хориод адуу;* 2. тусбүр хорь; *хүн бүрд хориод ногдох.*

ХОРИОТОЙ цээртэй, үл болох, үл зөвшөөрөх, хориглосон нь; *хориотой тоглоом; хөл хориотой айл;* **тамхи татах хориотой** (тамхи татаж үл болно).

ХОРИУЛ I хорин юм хамт; *бид нутгаасаа хориул гарав.*

ХОРИУЛ II 1. хорих, халхлах хаалт; *усны хориул; малын хориул; хориул барих;* 2. хорио, цээр; *хориул тавих.*

ХОРИУЛАХ 1. хорихын үйлдүүлэх хэв; 2. хоригдох.

ХОРИУЛГҮЙ хорио цээргүй; *хориулгүй хэрэг.*

ХОРИУЛТАЙ хорио цээртэй; *хориултай газраар явж болохгүй!*

ХОРИХ 1. хориглох; *гажуу бурууг цаазлан хорих; хэрүүл зодооныг ятган хорих;* 2. хаах боох; *адгуус малыг хашаалан хорих; ус урсгалыг бооож хорих;* 3. хорио цээр байгуулах; *хөл хорих; явахыг нь хорих;* 4. хааж хадгалах; *гянданд хорих;* **хорих өөш** (загас агнах зэвсэг, урсгал усанд хэрэглэнэ).

ХОРЛОГДОХ хорлохын үйлдэгдэх хэв, хөнөөгдөх; *амь хорлогдох.*

ХОРЛОГЧ (ИН) хорлохдоо дуртай хүн; **хорлогчин санаа** (хорлох муу санаа).

ХОРЛОЛ хорт аргаар хөнөөх хөнөөл; **хорлол хөнөөл** х о р ш..

ХОРЛОЛТ ямагт хүнийг хохируулан, эвдэн явдаг, хорлол бүхий; *хорлолт амьтан.*

ХОРЛОЛТОЙ хорлол бүхий аливаа юм; *чоно-хорлолтой дайсан; оготно-билиээрт хорлолтой амьтан.*

ХОРЛОХ юмыг алах, зовоох, хохируулах зэргээр хор хүргэх, хөнөөх, эвдлэх; *хорлох; бодлогоор үйлдсэн нь илт; бусдын амийг хорлох; эд хөрөнгийг сүйтгэн хорлох.*

ХОРЛУУЛАХ 1. хорлохын үйлдүүлэх хэв; 2. хорлогдох.

ХОРМОГЧ нэгэн зүйл хувцас, арьс бөс зэргээр хийнэ, бэлхүүснээс доош, хувцасны гадуур давхацлан өмсөнө.

ХОРМОЙ 1. дээл, цамц, дээвэр туурга, хувцас хэрэглэлийн доод этгээдийн зах; **хормой шуух** (хормойгоо бүсэндээ хавчуулах зэргээр дээш сөхөх; *уул үзээгүй хормой шуух, ус үзээгүй гутал тайлах);* **хормой огших** (дээлийн хормой дээш эргэх); **хормой хот** (хормой; *хормой хотоо тат!);* **хормойн донтой, хормойд нь салхи орох** (гэр орондоо тоттноож чадахгүй дэмий хэсүүчлэн тэнэх болсон, тэнэмхий); **хормой дэвсэх** (хормойгоо газар дэлгэх; *хормой дэвсч, хушуу цорвойж гуйх);* **хормой сөхөх** (хормойг дээш буюу гадагш өргөж хөндийлөх); 2. уулын бэлийн доод этгээдийн газар; *тэр уулын хормойд хэсэг хонь билчээрлэж явна;* ☆ **тэнгэрийн хормой** (тэнгэрийн хаяа, алсад газар тэнгэр хоёрын нийлсэн мэт харагдах зааг).

ХОРМОЙВЧ эмэгтэйчүүдийн нэгэн зүйл гоёлын хувцас, торго торгомсгийн зүйлээр хийнэ, чимхээр зах тавьж, хуниас гаргасан хормогч.

ХОРМОЙДОХ хормойноос барьж татах, чангаах.

ХОРМОЙДУУЛАХ 1. хормойдохын үйлдүүлэх хэв; 2. хормойдогдох.

ХОРМОЙЛОХ хормойдоо юм хийх; *аргал хормойлох.*

ХОРМОЙЛУУЛАХ 1. хормойлохын үйлдүүлэх хэв; 2. хормойлогдох.

ХОРОВ 1. а м ь т а н аврага загасны нэгэн зүйл, ам урт шовхгор, хайрсгүй, нурууны журам хажуугийн газарт гурван журмаар наалдсан яс бүхий, арьс зузаан нэгэн зүйл загас, том нь нэг хос алд илүү бий; 2. аварга загасны өөр нэр.

ХОРОВГОР хавтгай юмны нэгэн тийш баахан атирч хумирсны нь; *хоровгор адсага.*

ХОРОГДОЛ хорогдох үйлийн нэр, хорогдсон юм; **элэгдэл хорогдол** х о р ш.; *хорогдол ихтэй; малын хорогдол их багасч байна.*

ХОРОГДОХ хорохын үйлдэгдэх хэв, хасагдах, цөөрөх; *нөөц бэлтгэл хорогдох.*

ХОРОГДУУЛАХ хорогдохын үйлдүүлэх хэв.

ХОРОЛ I хэгээс бүхий цагариг дугуй юм; *хорол тооно; хорол хээ; хорол дугуй.*

ХОРОЛ II нэгэн зүйл тоглоом, хорол, чандмань, хас, гарди ба жилийн арван хоёр эрхтний дүрс бүхий зүйлээр даалуу мэт наадах тоглоом; *хорол наадах.*

ХОРОЛДОХ хорол тоглоомоор наадах.

ХОРОЛЗОХ зарим юм салхинд мөргөгдөн эргэлзэх, хоргох; *ус салхинд хоролзох.*

ХОРОМ 1. цагийн хэм, нэгэн нарийн хувь буюу секундийг арван мянга хуваасны нэг; 2. маш түргэн; *хором зуур.*

ХОРОМЖ хорогдол, хорохуй.

ХОРОМЖГҮЙ хорогдолгүй.

ХОРОМЖИТ: хоромжит нөхөр нэр гутаах муу нөхөр.

ХОРОМЖТОЙ 1. хорогдолтой; 2. илүүтэй биш, илүүдэх юм биш; *хоромжтой юм биш, хэлээд үз л дээ.*

ХОРОМСОГО нум дүрэх сав.

ХОРОМХОН цагийн хэмийн маш түргэн, түргэн зуур, агшин зуур; *хоромхон зуур сүрхий ширүүн салхи гарав.*

ХОРОН I санаснаас хурдан хорогдох, барагдах нь; **хорон хомс** х о р ш.; *ямар хорон юм бэ, бараг тэхий хагас нь алга болж орхив.*

ХОРОН II тэчьядам, зэвүүрхэм, хортой; *хорон үг; хорон үгээр дайрах;* **хорон хамхаг** у р г а м а л (говь талын бүсэд ургадаг нэгэн наст ургамал, хатсан үед нь тэмээ болон бог мал сайн иднэ): **хорон хажир** (а. хорон хамхаг өвс; б. малд зохимжгүй хужир шорвогийн зүйл; в. хүний муу үгтэй, дайрамтгай зантай; г. хувцас хунарт гам хайргүй, бүрэлгээч; д. юмыг их хороомтгой).

ХОРОО 1. хүрээ, хашаа; *малын хороо; хашаа хороо засах;* 2. хот суурин газрын засаг захиргааны нэгж; *Нийслэл хотод олон хороо бий; Найрамдлын хороонд оршин суугч; хорооны дарга* 3. дивиз буюу бригадад багтах цэргийн хэсэг анги; *хуяг танкийн хороо; хороо цэрэг;* 4. ямар нэгэн ажлыг эрхлэн удирдах байгууллага; *төв хороо; бэлтгэх хороо; зохиолчдын хороо; хэвлэлийн хороо; утасны хороо.*

ХОРООЛОЛ хороолох үйлийн нэр.

ХОРООЛОХ хүрээлэх, хашаалах; 2. хороо болгох.

ХОРООХ I хорохын үйлдүүлэх хэв, цөөрүүлэх, багасгах, хорогдуулах; *газар хороох; тоогий нь хороох; хоол хороох.*

ХОРООХ II ялтан хүнийг цаазлан алах.

ХОРОХ I цөөрөх, багасах, хасагдах; *тоо нь хасагдаж хорох; хэмжээ нь багасч хорох; зудад мал хорох; нас хорох.*

ХОРОХ II их халуунд зарим малын хурж бөөгнөрөх; *энэ өдрийн халуунд хонь хороод, олигтой идшилж чадсангүй; хорж хэвтэх.*

ХОРСГОЛ хорсол, өшөө.

ХОРСГОХ хорсоход хүрүүлэх.

ХОРСОЛ дотор агуулсан тэчьядах буюу занах сэтгэл; **өшөө хорсол** х о р ш.; *хорсол төрөх; хорсол хадгалах.*

ХОРСОХ I бие махбод эрхтний халуу оргиж шимшрэн эрхэрч өвдөх; *биеийн арьс нялтран хорсох нь зовиуртай байна; шарх дээр исгэлэн юм хүрч нэндүү хорсох болов; нүдэнд давс орвол ихэд хорсох ёстой; халуун буюу исгэлэн амттыг хэтэрхий идвэл дотор маш хорсох.*

ХОРСОХ II сэтгэлд тэчьядах буюу харамсах санаа төрөх; **нүд хорсох** (хэтэрхий зэвүү хүрсэн юмаа үзэх харахад нэн их зэвүү хүрэх болох).

ХОРТ хор бүхий юм; *хорт дайсан; хорт сэтгэл; хорт чоно;* **хорт могой** (зуувал хор бүхий могой); **хорт бодис** (хордуулах бодис); **хорт уур** (хор болох, газрын муу уур амьсгал); **хорт эм** (хордуулах эм); **хорт хавдар** (үхэлд учруулахад хялбар аюултай, халдварт өвчин).

ХОРТИГ: хортиг яр хошгиногийн дотоод гадаадад гарах гөвдрүү.

ХОРТОЙ 1. аливаа хор бий юм; *хортой өвс;* 2. хүний хорсол, атаархал сэтгэл ихтэй; *хортой хүн; хортой шартай амьтан;* **хортойгоор хэрэглэх, ашиглах** (аливаа юмыг бурууд хэрэглэх; *өндөр албан тушаалыг хортойгоор хэрэглэх);* **хортой харандаа** (балыг норгож бичвэл бэх мэт гардаг тусгай голтой харандаа).

ХОРТОН I хор бий амьтад; *хортон дайсан;* **хортон араатан** (амьтанд хор хийх барс, ирвэсийн зэрэг зэрлэг амьтад).

ХОРТОН II гөлгөр хатуу юманд бий болсон сэв, ар; *толины хортон; чулууны хортон: хортон гарах; хортонгий нь арилгах.*

ХОРТОНТОХ хортонтой болох, хортон суух; *шаазан хортонтох.*

ХОРТОНТУУЛАХ хортонтохын үйлдүүлэх хэв.

ХОРХИНОГ у р г а м а л вандуйн төрлийн нэгэн зүйл ургамал.

ХОРХИРОО хонинд тохиолдох нэгэн зүйл хүнд халдварт өвчин.

ХОРХИРООТОХ хонинд хорхироо өвчин тусах.

ХОРХОГ 1. махыг арьстай нь эсвэл тусгай тулам гүзээ зэрэг саванд хийж дотор нь улайтгасан чулуу дүрж болгосон хоол; *хорхог идэх*; 2. ургамал, үр тариа, мах ясны зэрэг юмыг усанд улбартал чанаж, хамаг шим шүүсийг буулган боловсруулж авахы нь; **хорхог ханд** х о р ш.

ХОРХОГЛОХ хорхог хийх, хорхог болгох.

ХОРХОГЛУУЛАХ хорхоглохын үйлдүүлэх хэв.

ХОРХОЙ 1. олон эст амьтны аймагт багтах сээргүй амьтад: **хорхой шавьж, өт хорхой, ялаа хорхой** х о р ш.; **цох хорхой** а м ь т а н (хатуу давхар далавчтай шавьж); **чийгний хорхой** а м ь т а н (ус чийгтэй газар төрж орших, нялцгай биет хорхой); **шанаган хорхой** а м ь т а н (газар усны сүүлгүй амьтан, мэлхийн, авгалдай); **олгой хорхой** (маш их хортой амьтан, говьд байдаг гэдэг); **урт хорхой** (могойн цээрлэсэн нэр); **хорхой идэх** (а. жижиг эрвээхийн олон хөлт өт ноосон эдлэлийг гэмтээн сүйтгэх; *хорхой идсэн хөшиг*; б. шүдний яс ялзран үрэвсэх; *шүд хорхой идэх*); 2. өт хорхой хэлбэртэй: **хорхой ааруул** (аарцыг шанаган шүүр мэт олон нарийн нүхтэй зүйлээр шахан гоожуулж тавьсан ааруул); ☆ **хорхой хялгас** (адууны сүүлд ургасан хугарсан бүдүүн охор хялгас); **хорхой үс** (залуу хүний толгойд ургах цагаан үс); **хорхой хөдлөх, хорхой хүрэх** (ихэд шохоорхох, дурлах); **хорхойгоо дарах** (бяцхан идэх мэтээр хүслээ хангах төдий болох); **хорхой гозгонох** (хорхой нь их хүрэх); 3. ш и л ж с э н шохоорхох сэтгэл, шунах хүсэх сэтгэл: *хорхой хүрмээр сайхан байшингууд харагдав;* **хорхойгий нь хүргэх** (хүний ямар нэгэн юманд хүсэл дуры нь татаж өдөөх); **хорхойгий нь хөдөлгөх** (хорхойгий нь хүргэх).

ХОРХОЙЛГОХ хорхойхын үйлдүүлэх хэв.

ХОРХОЙЛОХ хорхойгий нь хүргэх.

ХОРХОЙСОХ 1. хүний юманд хүсэн дурлах; 2. хорхой хүрэх.

ХОРХОЙТОЙ 1. хорхой бүхий, хорхой ихтэй, хорхой элбэгтэй; 2. могой ихтэй; 3. шуналтай, дуртай; *зураг зурахын хорхой болсон хүн; хурдан морины хорхойтой.*

ХОРХОЙТОХ 1. өт хорхой бий болох; *энэ ус хорхойтож орхисон байна;* **шүд хорхойтох** (шүдний яс ялзран үрэвсэх); **баавгай хорхойтох** (а. шоргоолж идсэнээс болж өвдөх өвчин; б. хоолгүйгээс болж ой модноос гарч тэнэх); 2. хүний юманд шунан дурлах.

ХОРХОЙХ санаа зовниж, царай хувьсан гонсойж зогсох.

ХОРХОРХИЙХ хор хор гэж дуу гарах; *тогоотой хоол хорхорхийн буцалж байв.*

ХОРЧГИР 1. амьтны хатангир дорой, царай нь харалж гутсан буюу харчгар туранхи; 2. арчгар, үрчгэр, арьс шир зэргийн хорвойн атирч хатсаны нь.

ХОРЧГОНОХ хорчгор юмны үргэлжлэн хөдлөх.

ХОРЧГОР үрчгэр, хоржгор.

ХОРЧИГНОХ үргэлжлэн хор хор чимээ гарах; *горхины ус хорчигнон урсч байна.*

ХОРЧИГНУУЛАХ хорчигнохын үйлдүүлэх хэв, хорчгонон дуугаруулах.

ХОРЧИЙЛГОХ хорчийхын үйлдүүлэх хэв, хорчгор болгох.

ХОРЧИЙХ хорчгор болох; **үрчийх хорчийх** х о р ш.

ХОРЧИЛЗОХ хорчгор юмны байн байн хөдлөх.

ХОРЧИЛЗУУЛАХ хорчилзохын үйлдүүлэх хэв.

ХОРЧИН Өвөр монголын нэгэн аймгийн овгийн нэр.

ХОРШИЛДОХ хорших II-ын үйлдэлдэх хэв.

ХОРШИХ I 1. хольж найруулах; *таргий сүүгээр хорших; гурилд тос хорших;* 2. юмыг хоршуулаар хутгах, зуурах; *тараг хорших; аарц хорших.*

ХОРШИХ II хамтран нийлэлдэх, хоршоо болох; *хоршиж хийх.*

ХОРШИХ III хорны шинжтэй болох; *наад хоол чинь бүр хоршиж орхилоо.*

ХОРШИЦГООХ олноороо хорших.

ХОРШОО 1. санал хүчээ нэгдэн хавсарч эд хөрөнгөөр буюу биеийн хүчнийг хамтруулан байгуулсан нэгдэл; **хоршоо холбоо** х о р ш.; *хоршоо нөхөр; харилцан туслалцах хоршоо;* 2. ш и л ж с э н дэлгүүр; **хоршоо худалдаа** х о р ш.; *хоршоонд очих; хоршоонд түүхий эд тушаах; хоршоодын холбоо.*

ХОРШООЛДОХ хүмүүсийн харилцан сугадалцаж явах.

ХОРШООЛОЛ 1. хоршоолох үйлийн нэр; 2. хоршоо, нэгдэл; *үйлдвэрийн хоршоолол; гар урлалын хоршоолол.*

ХОРШООЛОХ аливаа үйл явдалд хөрөнгө хүчин, санал харилцан нэгдэж нөхөрлөх, хоршоо болох; *хоршоолсон аж ахуй.*

ХОРШООЛУУЛАХ хоршоолохын үйлдүүлэх хэв.

ХОРШУУЛАХ I хоршихын үйлдүүлэх хэв.

ХОРШУУЛАХ II хорших III-ын үйлдүүлэх хэв, хорны шинжтэй болгох.

ХОРЬ (ХОРИН) I 1. арав дээр арвыг нэмсэн тоо; *хорь дахин; хорь хүрэх; хорин тав; хорин хүн;* 2. сарын хорины өдөр; *өнөөдөр хоёрдугаар сарын хорин;* 3. хотын засаг захиргааны байгууллагын үндсэн нэгж; *хорины дарга; арван тавдугаар хоринд оршин суух.*

ХОРЬ II Буриадын нэгэн аймгийн овгийн нэр.

ХОРЬДУГААР дэс тооны хорь; *бид хорьдугаар зуунд амьдарч байна; хорьдугаар хаалга; хорьдугаар дэвтэр.*

ХОРЬТ хорин тоо бүхий; *хорьтын цагаан мөнгө.*

ХОС I хонь малын олгой хошгиног хоёрын хооронд нугаран цагариглаж тогтсон бүдүүн гэдэс; **хос хошгиног** х о р ш..

ХОС II 1. адил, хоёр, угаасаа хоёроор хэрэглэх зүйл; *гутал нэг хос; гурван хос оймс;* 2. хоёр тоотой юм; *хос морь хэрэглэн явна;* **хос алд** (хоёр алд, метрээр 3 м. 2 см.): **хос холбоо** (ханилсан эр-эм хоёр); 3. ижил; **ижил хос** х о р ш..

ХОСГҮЙ ижилгүй, ханигүй; *хосгүй мэргэн эрдэмтэн; ертөнцөд хосгүй цэвэр өнгөтэй; хосгүй дуутай хүн.*

ХОСЛОЛ хослох үйлийн нэр.

ХОСЛОХ юмыг ижил хос болгох; *морь хослон унах.*

ХОСЛУУЛАХ хослохын үйлдүүлэх хэв.

ХОСХ I а м ь т а н халимын язгуур, олон шүдтэй, загас идэштэй, гахайн адил өөхтэй, өөхий нь арьс шир боловсруулахад хэрэглэнэ.

ХОСХ II нүх ухахад хэрэглэдэг маш богинохон бариултай модон хүрз; *тарвагачны хосх.*

ХОТ I 1. нэгэн газар олон хүн хуран цугларч, орон барилга цогцлон суурьшсан бөгөөд бас ч үйлдвэр, худалдаа, засаг захиргааны байгууллага төвлөсөн газар; *хотын хүн ам; хотын цэцэрлэг;* **нийслэл хот** (улсын засгийн газар болон засаг төрийн албан байгууллага орших төв хот); **хот орох** (хөдөөгөөс хотод очих); **хотын хөдөлгөөний дүрэм** (хотын дотор ердийн ба авто хөсөг, хүмүүсийн явах дүрэм); 2. хөдөө газар, айл өрх нэг заримаар буюу хэд хэдээр хамтран буудалласны нь; *хот айл; хот өрх; хот тосгон.*

ХОТ II мал гөрөөсний хэвтэшлэх газар; *хонины хот; хотоо манахад хориулан болоосой.*

ХОТ III хонь малын ур тогтох хэвтэш; *урийн хот.*

ХОТ IV малын далны ясны хамрын хажуу этгээдийн уудам газар; *далны хот; хот сайтай дал.*

ХОТ V цахиур бууны дарь агуулах сав, эвэр буюу булигаар арьс мэтээр хийнэ: **хот цэнэг** х о р ш..

ХОТГО шавраар үйлдсэн ваар сав.

ХОТГОЙД Монголын нэгэн аймаг овгийн нэр.

ХОТГОНОХ хотгор юмны үргэлжлэн хөдлөх.

ХОТГОНУУЛАХ хотгонохын үйлдүүлэх хэв.

ХОТГОР гүдгэрийн эсрэг утга, юмны хэвийн жишээнээс доош хотойсны нь; *хонхор хотгор газар; хотгор мууртай морь.*

ХОТГОРДОХ хэтэрхий хотгор болох.

ХОТГОРХОН нилээд хотгор, баахан хотгор.

ХОТИР бөөрөлзгөнийн өөр нэр.

ХОТЛООР бүхэн, бүгдээр, цугаар; *гэр хотлоор амгалан уу?*

ХОТЛОХ 1. мал тэжээврийн хот хэвтэшдээ орох; *мал хотлох;* 2. хот болох; *хотолж буух.*

ХОТЛУУЛАХ хотлохын үйлдүүлэх хэв; *мал хотлуулах.*

ХОТОЙЛГОХ хотойхын үйлдүүлэх хэв.

ХОТОЙХ 1. хотгор болох; *нируу хотойх; хамар хотойх;* 2. ш и л ж с э н эд хөрөнгө хомсдох, багасах; *хөрөнгө нь хотойх.*

ХОТОЛ I хандгайн зулзага.

ХОТОЛ II бүх даяар, бүрэн төгс, нийт; *хотол олноороо цугларав;* **хотол чуулган** (аливаа юм бүрэн төгс); **хотол баясгалант хурим** (хүн маш хурж, хамаг сайн сайхан бүхэн бүрдсэн хурим).

ХОТОЛГООР хотлоор, бүгдээр, даяар; *аймаг хотолгоор; гэр хотолгоор; өрх хотолгоор.*

ХОТОЛЗОХ хотгор юмны хотос хотос хийх.

ХОТОЛЬ хоёр настай эр тарвага, бозлог.

ХОТОН I а м ь т а н хун шувуутай адилхан болоод үнсэн өнгөтэй, хушуу өргөн, эрүүндээ хөөтэй, сүрэглэн явдаг нэгэн зүйл шувуу, загас барьж амьдарна.

ХОТОН II тай; *өртөөний хотон; харуул хотон.*

ХОТОН III хуй хуй үндэстэн; *хотон ястан; хотон аймаг.*

ХОТОЧ хотоо сахиж хамгаалахдаа сайн; *хоточ нохой.*

ХОТОЧЛОХ хоточ нохойн хотоо эргэн тойрон харгалзаж явах.

ХОХИВГОНОХ хохиволзох, хохигонох.

ХОХИВОЛЗОХ 1. муухай ааштлах; 2. хохилзох, хохигонох.

ХОХИВОЛЗУУР хохиур зан ааштай.

ХОХИГОНОХ 1. хохиволзох, хохилзох; 2. хохиур, дохиур ааш гаргах; *нэг өвгөн хохигоноод юу ч хэлж өгсөнгүй.*

ХОХИГОР өндөр нарийн, муруй тахир юм; *хохигор уурга; хохигор ганц мод.*

ХОХИЛЗОХ 1. хохиур зан байдал гаргах; 2. хохиволзох, хохигонох; 3. хохигор юмны хохис хохис хөдлөх.

ХОХИЛЗУУР хохиволзуур.

ХОХИМОЙ хүний хэлхмэл яс мөн толгойн яс; *хохимой яс; хохимой толгой.*

ХОХИНОХ хоолойн орчин бачим бүгт дуу гарах, хохтнох ч гэнэ; *хоолой хохинох.*

ХОХИО маш дорой, ядуу байдалтай хүн.

ХОХИР ёхир муу зантай, хохиур.

ХОХИРОГДОХ хохирохын үйлдэгдэх хэв.

ХОХИРОГЧ хохирсон этгээд, хохьдогч.

ХОХИРОЛ алдал, алдагдал, хөнөөл, сүйтгэл; **хохирол сүйтгэл** х о р ш.; *хохирол учрах; хохирол болох.*

ХОХИРОЛГҮЙ хохирол хүлээгээгүй, алдал алдагдал болоогүй.

ХОХИРОЛТОЙ хохирол хүлээсэн, хохирол бүхий.

ХОХИРООХ хохироход хүргүүлэх; *хүнийг хохироох хэрэггүй.*

ХОХИРОХ алдагдал болох, элэх, хорох, хор хөнөөл олох; *эд хохирох; алдаж хохирох; амь хохирох.*

ХОХИРУУЛАХ хохирохын үйлдүүлэх хэв.

ХОХИУР 1. хүний царай нүүрийн мах бага, яс арьсны төдий шахам туранхи; 2. хүний хажиг муухай ааштайгий нь; **хохиур дохиур** х о р ш.; *хохиур зантай хүн.*

ХОХОЙ: халаг хохой зовлон бэрхшээлтэй явдал тохиолдоход хэрэглэх аялга; *хохой халаг-*

ХОХОЙЛОХ халаглах, гаслах.

ХОХТНОХ хоолой хохинон хуухинан дуугарах.

ХОХЬ 1. зайлшгүй тохиосон алдагдал хохирол, золгүй явдал; *хөрөнгө хоосорч хохь болов; олсон миний зол, алдсан чиний хохь;* 2. ор ганц, цор ганц; *хохь ганц; хохь толгой;* **хохь хоосон** (биеэс өөр юу ч үгүй); **хохь болох** (хохирох, хоосрох, ганцаар болох); ☆ **хохь**

чинь (хүнийг тавлах үг; *ятгахыг сонсохгүй ийм алдагдал болсон хохь чинь! мэдсээр байгаад хийсэн хохь чинь дээ*); **хохь тайж** хуучирсан (албат хамжлагагүй тайж).

ХОХЬДОГ 1. зөвхөн хар амиа боддог, гань ганц байдалтай; 2. хохиур муу зантай.

ХОХЬДОГЧ хохирол хүлээсэн этгээд; *хохьдогч этгээд.*

ХОХЬДОЛ хохирол, алдагдал.

ХОХЬДОХ I хохирох, хохирол үзэх.

ХОХЬДОХ II хэтэрхий хохь болох, хохийн учир нийлэмжгүй болох.

ХОХЬДУУЛАХ хохьдохын үйлдүүлэх хэв.

ХОЦОРГОХ хоцрохын үйлдүүлэх хэв, үлдээх.

ХОЦРОГДМОЛ хоцрогдсон юм.

ХОЦРОГДОЛ хоцрогдож яваа нь; *колони орнуудын эдийн засгийн хоцрогдол.*

ХОЦРОГДОЛГҮЙ зэрэгцэн явж байгаа, бусдаас хоцрогдохгүй.

ХОЦРОГДОХ 1. хоцрохын үйлдүүлэх хэв; 2. орхигдох, хаягдах, сүүлдэх.

ХОЦРОЛ хоцрох үйлийн нэр.

ХОЦРОЛГҮЙ хоцрохгүй, үлдэхгүй, орхигдохгүй, хаягдахгүй, сүүлдэхгүй.

ХОЦРОНГҮЙ хоцорч яваа; *хоцронгуй орон; сурлагын талаар хоцронгуй явж байна.*

ХОЦРООЛГҮЙ орхиж үлдээлгүй; *бүх ажилчдаас нэгий ч хоцроолгүй ирүүл!*

ХОЦРООХ 1. хоцрохын үйлдүүлэх хэв; 2. орхиж үлдээх.

ХОЦРООХГҮЙ хоцроолгүй, үлдээлгүй, орхилгүй.

ХОЦРОХ урьтаж буюу зэрэгцэж чадахгүй үлдэх, хожимдох, сүүлдэх; *бид яваад тэд хоцрох; хүрдан морь нь тасарч гараад, энгийн морь сүүлд нь хоцрох; сэргэлэн нь сурч мэдээд авахад дорой нь мэдэлгүй хоцрох; эцэг эхээсээ өнчрөн хоцрох.*

ХОЦРОХГҮЙ үлдэхгүй, хожимдохгүй, зэрэгцэж явах.

ХОЧ 1. бусдад шоодон өгсөн нэр цол; *хоч өгөх; нэг нэр, хоёр хоч;* 2. хач; **хач хоч** хорш.; *миний хэлсэн хийсэн юманд хоч хачгүй юм байхгүй;* 3. гооч; *хочий нь барав.*

ХОЧЛОЛ 1. хочлох үйлийн нэр; 2. хачлах нь.

ХОЧЛОХ 1. хоч нэр өгөх; 2. хачлах, хач тавьж хэлэлцэх.

ХОЧЛУУЛАХ 1. хочлохын үйлдүүлэх хэв; 2. хочлогдох.

ХОШ I хуучирсан сул дагалцан явах хөтөч хүн.

ХОШ II юмны зах хөвөөний дотуур тойрон даруулж оёсон нарийн мөшгөөр.

ХОШ III: **хош худрага** бөс нугалан үйлдэж сэхэвч эсгий тавьж хийсэн худрага.

ХОШ IV: **хоол хош** хоол юм.

ХОШГИНОГ хүн амьтны олгойн дорхи хос гэдэсний нугалаанаас доош өтгөн мөр үзэх сүв хүртлэх хэсэг; **хошгиногийн гүвдрүү** (өтгөн мөр үзэх сүвний дотоод ба гадаад орчинд гарах яр өвчин).

ХОШГО хосх II.

ХОШГООД хошоод.

ХОШИГНОХ хошин зан байдал гаргах.

ХОШИГНУУЛАХ хошигнохын үйлдүүлэх хэв.

ХОШИД I Монголын дөрвөн Ойрдын нэг аймгийн нэр.

ХОШИД II ургамал амт шидийн адил болоод цөмөө нь бяцхан нэгэн зүйл шид.

ХОШИН I ямар нэгэн сонирхолтой, инээдэмтэй үг өгүүлэл буюу бүжиг тоглоомын зэрэг зүйл; **алиа хошин** хорш.; *хошин үг; хошин зан;* **хошин үзэгдэл** (богино хэмжээний инээдэмт жүжиг).

ХОШИН II: **хошин мөөг** ургамал модны үндэс, тайрдсанд ургадаг мөөг, төрөл зүйл хэд хэд, заримыг идэж болно.

ХОШИНЛОХ хошигнох, хошин үгээр хэлэлцэх.

ХОШИНЧ алиа хошин зантай хүн.

ХОШИНЧЛОХ хошин үгээр цаашлуулах.

ХОШЛОН эсрэг тэсрэг эрчтэй дээсийг хоёр буюу гурав дөрвөөр зэрэгцүүлэн оёсны нь; *гэрийн хошлон; хошлон бүслүүр; хошлон дээс.*

ХОШЛОХ: нар хошлох нарны гэрэл, агаарын буданд тусч нарыг тойрон дугараг буюу хоёр этгээд эсвэл дөрвөн этгээдэд туяа гарч үзэгдэх, нар хүрээлэх ч гэнэ; *нар хошлох.*

ХОШМОГ юмны зах хормойгоор янзалж хөвөөлсөн эмжээрийн дотуур нарийн хосолсон хош мөшгөөр; *хошмогтой хантааз; хошмогтой дээл.*

ХОШНОГО хошгиног; **хошного чихэх** (малын хошногод мах өөх зэргийг алаглуулан хийх); **хошного урвах** (цагаан мах гарах); **хошногийн түрий** (хошногийн бүдүүн үзүүр).

ХОШОЙ хоёр удаа, хоёрдугаар, хоёр дахь; *хошой баатар;* **хошой чин ван** х у у ч и р с а н (угсааны арван зэргийн тэргүүн зэргий нь); **хошой хатан** х у у ч и р с а н (хошой чин вангийн эхнэр); **хошой авхай** х у у ч и р с а н (хошой чин вангийн охин, хошой гэгээ ч гэдэг); **хошой тавнан** х у у ч и р с а н (хошой авхайтай холбосон эр, хошой гүнжтэй холбосон эр); **хошой гүнж** х у у ч и р с а н (хааны тэжээсэн охин).

ХОШОО солонголон хийсэн нарийн тууз.

ХОШООД хоёр, тусбүр хоёр ногдох юм; *хошоод хошоодоор нь өг.*

ХОШООНГОР у р г а м а л зэллэн ургадаг, хонгорцогтой нэг зүйл өвс.

ХОШООЧИН жигүүртний хамтарсан эр эм хосоорыг нь; *хошоочин нугас; хошоочин тогоруу.*

ХОШООНЧ чадамгай алиа хүн.

ХОШООНЧЛОХ хошин үгээр инээлгэх, хошин зан байдал гаргах.

ХОШРОХ хэтэрхий элбэгдэх, уртдах; *хоширсон дээл өмсөхөд зохимжгүй; хэтэрхий урт бүс хоширсоод бүслэхэд тувэгтэй.*

ХОШРУУЛАХ хошрохын үйлдүүлэх хэв.

ХОШУУ I хүн амьтны ам хамрын үзүүрийн тус газар; *шувууны хошуу;* **хошуу нэмэхээр хуруу нэм** (ажил хөдөлмөр хийж байхад ам яриа нэмэхийн оронд гар биеэр ажиллаж тусал); **хошуу цорвойх, хошуу дэвсэх** (а. бусдыг гуйж царайчлах; б. бусдыг аргадан элэгсэх); **хошуу хүргэх** (а. үнсэж таалах: б. хов хэлэх); **зэс хошуу өргөх, алтан хошуу өргөх** (бусдыг сэм ховлох); **алтан хошуу, зэс хошуу** (бусдыг сэмээр ховлон хов зөөдөг хүн); **таван хошуу мал** (хонь, ямаа, үхэр, адуу, тэмээ); **нохойн хошуу** у р г а м а л (иш мөчирт сондуу бүхий бутанд ургадаг жимс, өнгө улаан, амт хүчтэй, эмнэлэгт хэрэглэнэ).

ХОШУУ II орон нутгийн хүн ардыг баримтлан захирч түүний хэрэг зүйлийг эрхлэн гүйцэтгэж, аймгуудын удирдлагын дор захирагдаж байсан хувиар; *Хааны хошуу; Вангийн хошуу; засгийн хошуу; хошуу тамга; хошуу ноён; хошуу дарга; хошуу хийд; хошуу хүрээ;* **хошууны бээс** х у у ч и р с а н (урьдын цагт угсааны дөрвөн зэрэг хэргэмийн дөрөвдүгээр зэрэг); **хошууны хатан** х у у ч и р с а н (хошууны бээсийн эхнэр); **хошууны авхай** х у у ч и р с а н (хошууны бээсийн охин); **хошууны тавнан** х у у ч и р с а н (хошууны авхайн эр).

ХОШУУ III юмны шувтайж барагдсан үзүүр этгээд; *үүлын хошуу; үзэгний хошуу; гутлын хошуу;* **хадан хошуу** (гол буюу жалга руу шааж орсон уулын хамрын шувтрага хадан үзүүр); **бийрийн хошуу** (а. бийрийн зурах үзүүр; б. бийрийн үсийг хамгаалах дуг туй); **онгоцны хошуу** (онгоцны ус зүсэх өмнө үзүүр этгээд); **анжисны хошуу** (анжисны газар хагалах үзүүр этгээд).

ХОШУУ IV гурвалжин шовх хэлбэртэй юм; *хошуу торго; хошуу бин; өрхний хошуу;* **таван хошуу** (нэг зүйл тэмдэг).

ХОШУУД хошид I.

ХОШУУЛАХ хошуу болгох, хошуулдах ч гэнэ.

ХОШУУЛДАХ хошуу болгох, хошуу гаргах; **торго хошуулдах** (зөрүүлдэн хошуу гаргах); **өрх хошуулдах** (өрхний татдаг талыг хагас бүтээх).

ХОШУУЛДУУЛАХ хошуулдахын үйлдүүлэх хэв.

ХОШУУМАЛ I: **хошуумал сум** хошуут сумны адил болсод арай бяцхан сум.

ХОШУУМАЛ II: **хошуумал тутрага амуу** у р г а м а л хөгшилсөн тутрага амуугийн адил болоод амт муутай нэгэн зүйл будаа.

ХОШУУРАХ амьтны ямар нэгэн юм рүү түрүү татсанаа дагалдан цувах; *хонь, ус руу хошуураад гүйлдэв; галуу шувуу хошууран нисч явна.*

ХОШУУРУУЛАХ хошуурахын үйлдүүлэх хэв.

ХОШУУТ хошуу бүхий; **хошуут сум** (өнцөггүй сум): **хошуут туулай** а м ь т а н (янз туулайн адил, шувууны хошуутай адил нарийн урт хошуутай, могойн сүүл шиг, сүүлтэй, хүн үзэгдвэл унтсан мэт засдагладаг нэгэн зүйл амьтан, хошуут ан ч гэдэг).

ХОШУУЧ 1. хамгийн түрүүнд явагч, бусдыг дагуулагч; 2. цэргийн албан хаагчдад олгох нэгэн зүйл цол; 5. магнайн цэрэг; *хошууч анги.*

ХОШУУЧЛАХ хошууч болох, тэргүүлэх; *энэ ажилд намын гишүүд хошуучлан гүйцэтгэх хэрэгтэй.*

ХОШУУЧЛУУЛАХ 1. хошуучлахын үйлдүүлэх хэв; 2. хошуучлагдах.

ХОШХИРОХ 1. ямар нэгэн чимээ дохио болгож хоёр гараа атган амны тус барьж, дуу гарган үлээх; *эрэлчний хошхирох дуу сонсдов;* 2. намрын цагт гургуул шувууны дуугарцгаах; *намаршиж гургуул хорхирох цаг болов;* 3. тарвага цогцойн сууж хашгирах; *нүхнийхээ аман дээр нэг том тарвага хошхирч харагдав.*

ХОШХИЧИХ байн байн хошхирох, зэрэг зэрэг хошхирох, олноороо хошхирох.

ХӨВ I 1. усны тогтоол гүн газар; *голын хөв; нуурын хөв;* 2. усны урсгалын хаягдлаар хурамтлагдаж усны захад тогтсон хаягдал; *усны хөв; урсгалын хаягдал хөв; үерийн хөв;* 3. ой модны шилмүүс навчис унаж газрын хөрсөн дээр зузааран тогтсон сэвсгэр юмс; *ойн хөв; модны хөв.*

ХӨВ II удаан хадгалагдсанаас юмны чанарыг муудуулдаг нөлөөгий нь; *хөвт идэгдэх;* **хөв идэх** (үжирч чанар нь муудах); **хөвт дарагдах** (юмны, удтал хадгалагдаж үжрэн хэврэг болох)..

ХӨВ III хүч нэмэгдүүлэх үг; **хөв хөх** (балар хөх өнгө).

ХӨВГҮҮН хөвүүн.

ХӨВД 1. ойн доторхи бүдүүн өвс ургамал; *ойн хөвд ургамал нь шим тэжээлээр сайнгүй байдаг;* 2. ургамал ой модон дотор ургадаг, байдал хөвсгөр, өнгө ногоон, усны замагтай төсөөтэй нэгэн зүйл ургамал.

ХӨВӨГЧ хөвдөг юм; *хөвөгч завь.*

ХӨВӨЛЗӨХ хөнгөн чанарын юмны сэвэлзэн хөдлөх; *усны дээр завь хөвөлзөх; хомоол хөвөлзөх.*

ХӨВӨЛЗҮҮЛЭХ хөвөлзөхийн үйлдүүлэх хэв.

ХӨВӨН 1. ургамлын унгарил; *хөвөнгийн тариалан; хөвөн тавих;* **хөвөн зулах** (юманд хөвөнг нимгэн нимгэнээр тараах тавих); 2. **хөвөнгөөр** хийсэн юм; *хөвөн бараа; хөвөн даавуу;* 3. хөвөн шиг байдалтай; *хөвөн цагаан үүл;* ☆ **хөвөн оройт** ургамал (цайны оронд хэрэглэж болдог нэгэн зүйл навчит ургамал); **хөвөн өвс** ургамал (намаг газар ургадаг олон наст өвс, гөлөглөх үедээ хөвөн мэт үстэй болно).

ХӨВӨНЛӨГ: хөвөнлөг цаас торгомсог зөөлөн нэгэн зүйл цаас.

ХӨВӨНТЭЙ хөвөн тавьж хийсэн юм; *хөвөнтэй цамц; хөвөнтэй дээл.*

ХӨВӨӨ I 1. эд юмны амсар зах ирмэгийг мөшгөөрлөн тавьсан эмжээр ба хээ; *дээлийн хөвөө; аяга шаазангийн хөвөө;* 2. юмны хоёр хажуу зах; *голын хөвөө; замын хөвөө;* 3. зах, хязгаар; **зах хөвөө, хязгаар хөвөө** хорш.; *хөх цэнхэр далайн хөвөө хязгаар нутаг.*

•

ХӨВӨӨ II: **хөгшин хөвөө** хөгшин настай; *малынхаа хөгшин хөвөөгөөс идшиндээ хэрэглэдэг.*

ХӨВӨӨЛӨХ I 1. юмны хөвөөгөөр явах; *Сэлэнгийг хөвөөлөн уруудав;* 2. усны захаараа хөлдөх; *ус хөвөөлж хоносон байв.*

ХӨВӨӨЛӨХ II юманд хөвөө хийх; *зам хөвөөлөх; цонх хөвөөлөх; алчуур хөвөөлөх.*

ХӨВӨӨЛҮҮЛЭХ хөвөөлөхийн үйлдүүлэх хэв.

ХӨВӨРДӨХ 1. юмны зах уулзар ирмэгийг хэдрэн оёх; *эсгий хөвөрдөх; дээлийн дотор хөвөрдөх;* 2. шилжсэн дэмий тэнүүчлэн айл хэрж хэсэх; *айл хөвөрдөхөөс өөр ажилгүй;* 3. шилжсэн юмыг самнан явж эрэх, хайх; *гээсэн юмаа хичнээн хөвөрдөвч олж чадангүй.*

•

ХӨВӨРДҮҮЛЭХ хөвөрдөхийн үйлдүүлэх хэв.

ХӨВӨРХИЙ 1. хүвэрхий, хөвөрсөн юм; *зайдасны хөвөрхий;* 2. алдрах тайлагдахдаа хялбар, занги биш уясан уяа; *хөвөрхий уях; хөвөрхий зангидах.*

ХӨВӨХ I 1. нэхмэл юмны ширхгийг задлан цувах; *цуудас хөвөх;* 2. эвхсэн утас зэргийн алдран цувах; *утас хөвөх; дээс хөвөх;* 3. юмыг нарийн ширхгээр цувах; *унгас ноос хөвөх.*

ХӨВӨХ II усанд живэхгүй өргөгдөж дээр нь гарах; *онгоц усанд хөвөх; хөлгүй шахам усаар хөвж сэлсээр арай гэж гатлав.*

ХӨВСГӨР аливаа юмны зөөлөн сэвсгэр, овор бараа ихтэйгий нь; *хөвсгөр аргал; хөвсгөр жинтүү.*

ХӨВСИЙЛГӨХ хөвсийхийн үйлдүүлэх хэв, хөвсгөр болгох.

ХӨВСИЙХ хөвсгөр сэвсгэр болох.

ХӨВСӨГНӨХ хөвсгөр юмны үргэлжлэн хөдлөх.

ХӨВСӨЛЗӨХ хөвсгөр юмны байн байн хөдлөх.

ХӨВСӨРГӨН хөөргөн, онгиргон, сагсуу, ёргио хөнгөн байдалтай.

ХӨВСӨРГӨХ хөвсөргөн хөнгөн зан байдал гаргах.

ХӨВСРӨХ хөвсөргөн зан байдал гаргах.

ХӨВҮҮЛЭГ хүүхэд зантай.

ХӨВҮҮЛЭХ 1. хөвөхийн үйлдүүлэх хэв; 2. түүдрэлгүй шудрага ярих; *орсоор ч харин хөвүүлдэг хүн байна даа.* • ◆

ХӨВҮҮН эрэгтэй хүүхэд; *манай хөвүүн; тэдний хөвүүн;* **хөвүүн үе** (ах дүүгийн хүүхэд, биеийн нэг үеийн ураг төрлийн хүүхэд).

ХӨВҮҮЧЛЭХ бусдын хүүхдийг өөрийн үр болгон авах.

ХӨВХ I 1. усны дээгүүр хөвөн урсч яваа хөнгөн чанарын юм; 2. ойн ялзмаг хөв; *ойн хөвх.*

ХӨВХ II 1. бургасаар сүлжиж хийсэн авдар мэт сав; *дээлийн хөвх; малгайн хөвх;* 2. багвар сав; ☆ **хөвх зул** (хөвх сав дотор элдэв юмны дүрс өрөлж дээрээс өлгөөд имэрсэн дээсийг шатааж, ёроол алдарсан хойно дараа дараагаар зүйл бүрийн дүрс доош бууж ирэн, янз бүрийн гэгээ гэрэл цорхилон хаяж асдаг нэгэн зүйл наадам).

ХӨВХГӨР I дарах нухахад хонхойгоод, тавимагч хуучин хэвтээ буцаж орох байдалтай юм; *хөвхгөр дэвсгэр.*

ХӨВХГӨР II хөөргөн, ёргио, хөвсөргөн.

ХӨВХИЙЛГӨХ хөвхийхөд хүргүүлэх, хөвсгөр болгох.

ХӨВХИЙХ хөвхгөр болох.

ХӨВХИХ сэтгэл нь хөдөлж хааш аашлахаа олж ядах; *санаа хөвхих.*

ХӨВХЛӨХ I хөвхөд агуулах; *малгайгаа хөвхлөх.*

ХӨВХЛӨХ II хөвхөлзөх.

ХӨВХЛӨХ III сав юмыг хөвхөн болгох; *авдар хөвхөлж авав.*

ХӨВХЛҮҮР: **хөвхлүүр гүүр** гол горхинд түр барьсан хөөрөг.

ХӨВХӨГ хөнгөн хөөргөн хүн.

ХӨВХӨГНӨХ 1. хөвхгөр юмны хөвхөг хөвхөг хөдлөх; 2. зөөлөн хөнгөн нимгэн юмны хөдлөн дээш доош болох.

ХӨВХӨЛЗӨХ I хөвхгөр юмны хөвхөс хөвхөс хөдлөх, бамбалзах, намалзах, хотолзох.

ХӨВХӨЛЗӨХ II хөвсөргөн зан байдал гаргах.

ХӨВХӨЛЗҮҮЛЭХ хөвхөлзөхийн үйлдүүлэх хэв.

ХӨВХӨН хоёр хэлтэс хөндий хавсран нийлсэн юм: **хөвхөн авдар** (хөндий нээлхийтэй авдар); **хөвхөн самбар** (хоёр хэлтэс хөндий хавсран нийлэх самбар).

ХӨВХӨР I малын цагаан зүсэмд бяцхан хөх өнгө хольцолдсон зүсэм; *хөвхөр хонь.*

ХӨВХӨР II хөвсгөр; **хөвхөр хөвсгөр** х о р ш.; *хөвхөр зөөлөн хөрстэй газар;* ☆ **хөвхөр ямаа** (ямаан гөрөөс, янгир ч гэдэг).

ХӨВХРӨХ 1. идээний зүйлийн дотоод ялзран зөөлрөх; *мах хөвхрөх;* 2. уяж хатгаасан морины хатгаал тохирохгүй болон сулрах, муудах; *морь хөвхрөх.*

ХӨВЧ I уул нуруу зэргийн үргэлжилсэн өндөрлөг газар; *уул хөвч; хангай хөвч.*

ХӨВЧ II нумыг матируулан тогтоох мушгимал сур; *нумны хөвч.*

ХӨВЧ III хөвчин, бүх, хамаг.

ХӨВЧДӨХ I хэтэрхий хөвч болох.

ХӨВЧДӨХ II хөвөн, ноос үс зэргийг нумны хөвчид онуулан тавьж хөвчийг хөдөлгөн сэмчүүлж боловсруулах, унгас нумдах ч гэдэг; *ноос хөвчдөх;* ☆ **хөвчдөн алах** х у у ч и р с а н (хүний хүзүүнд дээс хөвчний зэргийг торгож мушгин үхүүлэх).

ХӨВЧИН бүх, хамаг; *хөвчин бие; хөвчин газар.*

ХӨВЧИРХИЙ мал гөрөөс зэрэг амьтны чив.

ХӨВЧЛӨХ I нуманд хөвчийг торгож тогтоох; *нум хөвчлөх.*

ХӨВЧЛӨХ II уулын хөвчийг дагаж явах.

ХӨВЧЛӨХ III юмны тэлэх татах; *тахилзуурын шөрмөс хөвчилж татаад байна.*

ХӨВЧЛӨХ IV хүч чадлаа шавхах; *онгодсон ажилдаа хүчээ хөвчлөн ажиллацгаая.*

ХӨВЧЛҮҮЛЭХ хөвчлөхийн үйлдүүлэх хэв.

ХӨВЧЛҮҮР нумны хөвчийг торгож тогтоох газар.

ХӨВЧРӨХ хөвч мэт татах; *шөрмөс хөвчрөх.*

ХӨГ I хөгжмийн аялгуу нийлэлдэхий нь; **хөг дуу** (хөгжмийн дуу); **хөг найруулагч** (дуу хөгжмийн аялгууг хянан нийлүүлэх хүн); **хөг нийлэх** (а. дуу хөгжмийн ая аялгуу зохицон найрах; б. аливаа юмны аяс шалтгаан найрах).

ХӨГ II хуц ухнын гүйхийг хориглож хүйсний өмнүүр дүүжлэн уях халхавч; *хуцын хөг;* **хөг зүүх** (хуц ухнад хөг хийх).

ХӨГ III 1. шившиг; **хөг шившиг** х о р ш.; *хөгөө хөлдөө чирэх;* **хөгөө тарих** (бусдад элэглэл шүүмжлэлтэй үйл ажил хийх, нууц хэргээ илрүүлэх, ичмээр үйл ажил хийх; *хөгөө тарьж, хөнжлөө хөлдөө чирэх);* 2. янзын, этгээд; *ямар хөгийн амьтан бэ.*

ХӨГЖИЛ хөгжих үйлийн нэр: 1. давшил, дэвшил; **хөгжил дэгжил** х о р ш.; *нийгмийн хөгжлийн хуулиуд;* 2. баясал, цэнгэл; *өвөөн аавын наян тавны найр болж бид их л хөгжил баясалтай байцгаав.*

ХӨГЖИЛДӨХ хөгжихийн үйлдэлдэх хэв, олноороо хөгжих.

ХӨГЖИЛТ давшилт, дэвшилт; *манай эх орны хөгжилт; мал аж ахуйн хөгжилт; үйлдвэрийн хөгжилт.*

ХӨГЖИЛТЭЙ хөгжил бүхий, баясал цэнгэлтэй; *хөгжилтэй яриа; хөгжилтэй хүүхдүүд.*

ХӨГЖИМ 1. сэтгэлийн хөдлөл, оюун бодол, хүсэл эрмэлзлэлийг айзамт хөг аяар илтгэн гаргадаг урлаг; **дуу хөгжим** х о р ш.; 2. бас мөнхүү зохиол; *бүжгийн хөгжим зохиох;* 3. хөгжмийн зохиол тоглох янз бүрийн хөгжмийн бүрэлдэхүүн хэсэг: **үлээвэр найрал хөгжим** (үлээдэг хөгжмийн зэвсгээр тоглох нэг зүйл найрал хөгжим; *улсын үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим);* **яруу тунгалаг найрал хөгжим** (чавхдаст, дэлдэх, үлээвэр хөгжмийн зэвсгээр бүрдсэн нэг зүйл найрал хөгжим; *яруу тунгалаг найрал хөгжмийн концерт);* **джазбонгийн найрал хөгжим** (ихэнхдээ дэлдэх, шуугиант хөгжмийн зэвсгээр бүрэлдсэн нэг зүйл найрал хөгжим); **дагшаа найрал хөгжим** (хөгжимдөх, хөгжимдөн дуулах, бүжиг, уран уншлага, хошин үзэгдэл, циркийн тоглолт зэргийг үзүүлэх нэг зүйл найрал хөгжим); **хөгжим анги** (хөгжимчдийн анги, хөгжимддөг бүлэг хүмүүс); **хөгжмийн удирдаач** (найрал хөгжим, найрал дуу, бүжгийн хөгжмийг удирдах хүн); 4. дуу аялгуу оруулан тоглох зэвсэг; *ятга хөгжим; баян хөгжим; лимбэ хөгжим; хөгжим үлээх; хөгжим цохих;* **хөгжмийн сургууль** (хөгжимдөгчдийг бэлтгэх сургууль; *хөгжим-бүжгийн дунд сургууль).*

ХӨГЖИМДӨХ хөгжмийн зэвсэг хэрэглэж, зүйл бүрийн эгшиг зохицуулах; *хөгжимдөж дуулах.*

ХӨГЖИМДҮҮЛЭХ хөгжимдөхийн үйлдүүлэх хэв.

ХӨГЖИМТ хөгжим бүхий; *улсын хөгжимт театр.*

ХӨГЖИМЧ (ИН) хөгжимдөхөд чадамтай хүн; *улсын театрын хөгжимч.*

ХӨГЖИХ 1. бадрах, дэгжих; *манай улсын соёл эдийн засаг улам бүр цэцэглэн хөгжиж байна; гал хөгжих; салхи хөгжих;* 2. баясах, хөөрөх; *сэтгэл хөгжих.*

ХӨГЖӨӨН наргиан, зугаа; *хөгжөөнтэй яриа; хөгжөөнгүй хүн.*

ХӨГЖӨӨНТЭЙ хөгжөөн бүхий, хөгжөөн ихтэй, наргиан ихтэй; *хөгжөөнтэй хүн.*

ХӨГЖӨӨХ хөгжүүлэх, хөгжихөд хүргүүлэх; *сэтгэлий нь хөгжөөх; гал хөгжөөх.*

ХӨГЖҮҮЛЭХ хөгжихийн үйлдүүлэх хэв; *эх орноо хөгжүүлэн цэцэглүүлэх.*

ХӨГЖҮҮН хөгжилтэй, хөгжөөнтэй.

ХӨГИЙ өвөл төрсөн хурга иших.

ХӨГЛӨРӨХ 1. эмх замбараагүй, ундуй сундуй болох; *олон хүүхэд багачуудтай хөглөрсөн айл; юм нь хөлөөр хөглөрөх;* 2. багшрах; *олон мал хөглөрөн билчээрлэж байна;* 3. гэлдрэх; *хөглөрөн хөдөлж ядах.*

ХӨГЛӨРҮҮЛЭХ хөглөрөхийн үйлдүүлэх хэв, хөглөрөхөд хүргүүлэх.

ХӨГЛӨХ I хөгжмийн аялгууг тохируулан найруулах, хөг тааруулах; *хөгжим хөглөх; төгөлдөр хуур хөглөх.*

ХӨГЛӨХ II хүний осол эндэгдэл их болж ичгүүртэй болох; хөг болох; *олон хүний дунд хөглөх шахлаа.*

ХӨГЛӨХ III ачсан тээсэн юмны унах, чирэгдэх; *ачаа хөглөх.*

ХӨГЛӨХ IV эмх замбараагүй, ундуй сундуй болох.

ХӨГЛҮҮЛЭХ 1. хөглөхийн үйлдүүлэх хэв; 2. хөглөгдөх.

ХӨГНӨ хурга ишгийг уяж торгох зэлэн дээс.

ХӨГНӨЛДӨХ өвс ургамлын харилцан шахцаж солбицон ургах.

ХӨГНӨХ хурга ишгийг хөгнөнд торгох; *хурга хөгнөх.*

ХӨГНҮҮЛЭХ 1. хөгнөхийн үйлдүүлэх хэв; 2. хөгнөгдөх.

ХӨГСИЙХ бусдын зүг хилэгнэн сэрхийх; *уурсан хөгсийх.*

ХӨГСӨӨХ хөгсөхөд хүрүүлэх, хүний хилэнг төрүүлэх өрнүүлэх.

ХӨГСӨХ хилэн төрж өрнөсөн байдал илрэх; *хилэн нь өрнөн хөврч хөгсөх.*

ХӨГСҮҮЛЭХ хөгсөхийн үйлдүүлэх хэв.

ХӨГТЭЙ I хөг зүүсэн; *хөгтэй ямаа явж байна.*

ХӨГТЭЙ II шившигтэй, сонирхолтой, гайхалтай.

ХӨГТЭЙ III хөг аялгуу сайтай.

ХӨГЦ I нэгэн зүйл хөх будаг; *чулуун хөгц; хөгц будаг.*

ХӨГЦ II аливаа зүйл бүгнэгдэн гутахад гарах бичил мөөг, ногоон шар өнгийн ваа. *ааруулын хөгц; хөгц амт; хөгц үнэр.*

ХӨГЦРӨӨХ хөгцрөхөд хүрүүлэх, хөгцрүүлэх.

ХӨГЦРӨХ хөгцтэй болох; *өрөм хөгцрөх; өөзгий хөгцрөх.*

ХӨГЦРҮҮЛЭХ хөгцрөхийн үйлдүүлэх хэв.

ХӨГШДӨХ дэндүү хөгшин болох, хөгшний учир тохиромжгүй болох.

ХӨГШДҮҮЛЭХ хөгшдөхийн үйлдүүлэх хэв.

ХӨГШИД өвгөд настан; **өвгөд хөгшид** х о р ш.; *өвгөд хөгшдийн сургаал үг.*

ХӨГШИН амьтан, ургамлын он удаж насжин муудсаны нь; *хөгшин хүн; хөгшин мал; хөгшин мод;* **хөгшин азрага жороо сурах** ш о о д с о н (хөгширсөн хойноо залуумсаг зан байдал гаргах, маяглах).

ХӨГШИНГӨ хөгшрөнгө.

ХӨГШЛӨГ залуу бөгөөтлөө хөгшин байдалтай.

ХӨГШЛӨХ хөгшнийг ялгах; **хөгшилсөн тутрага** (чийгтэй дулаан газар бүгнэгдүүлж, өнгийг шарангуй болгосон цагаан будаа, лоомий ч гэнэ).

ХӨГШРӨНГӨ нас залуу атлаа царай зүс өтөлсөн байдал.

ХӨГШРӨХ өтлөх, хөгшин болох, насжих; *залуудаа сурахгүй бол хөгширсөн хойноо гэмших.*

ХӨГШРҮҮЛЭХ хөгшрөхийн үйлдүүлэх хэв, хөгшин болгох.

ХӨДВӨР ёс журам мэдэхгүй хүн; *хөдвөр этгээд.*

ХӨДЛӨЛ хөдлөх үйлийн нэр; *хөдлөл ихтэй; хөдлөл багатай;* **газар хөдлөл** (газрын гадрагын хүчтэй хэлбэлзэл).

ХӨДЛӨЛТ хөдлөх үйлийн нэр; *газар хөдлөлт.*

ХӨДЛӨСХИЙХ 1. өчүүхэн хөдлөх; 2. нилээд сайн хөдлөх.

ХӨДЛӨХ 1. материйн тогтонги биш үргэлж хувиран өөрчлөгдөх; 2. хөдөлгөөнтэй байх; **гар хөдлөх** (а. жанчилдах зодолдох: б. амьдрахын төлөө ажиллах; *гар хөдөлбөл ам хөдөлнө* з ү й р; **хөл хөдлөх** (а. үймээн самуун болох; *хулгай дээрэм хөдлөх;* б. баяртай, хөгжөөнтэй үйл явдал болж хөхөлдөх); **үл хөдлөх хөрөнгө** (байшин хашаа, газар зэрэг байран хөрөнгө); **хөдлөх хөрөнгө** (хашаа байшин, газар зэргээс бусад эд хөрөнгө); **газар хөдлөх** (газрын гадрага хүчтэй хэлбэлзэн хөдлөх); **шороо хөдлөх** (салхинд шороо хийсэх); **ичигсэд хөдлөх** (сарны зурхайн ёсны жилийн хорин дөрвөн улирлын нэг, ичсэн амьтад унтсан нойроос сэрж ичээнээс гарах үе): **хөдлөх бүр, хөдлөх тутам** (үйл хэрэг тутамд ямар нэгэн үйл хэргийг зүй ёсноос ангидаар хэзээ ямагт хүсэх эрэлхийлэх; *хөдлөх бүр мөнгө урж зохихгүй; хэлэх бүр худал хэлж байдгаа боль!);* 3. хөдөлмөрлөх; *бид чадлаараа хөдлөх хэрэгтэй;* 4. үүсэх, төрөх, гарах; *салхи хөдлөх; шуурга хөдлөх;* **сэтгэл хөдлөх, санаа хөдлөх** (хөөрөн хөгжих санаа төрөх); **хор хөдлөх** (атаархах сэтгэл төрөх); **шар хөдлөх** (уур хилэн, бардам омог төрөх); **ааш нь хөдлөх, авир нь хөдлөх** (ямар нэгэн зан байдал гаргах; *сайхан ааш нь хөдлөх; муу ааш нь хөдлөх);* **өвчин хөдлөх** (хуучин оршсон өвчин дахин сэргэх); **чийг хөдлөх** (газар гэсч, чийг нойт дээш хөврч уурших); 5. байр сууринаас шилжих, нүүх, явах; *ачаа хөдлөх; би маргааш хөдөлнө; даан ч орой хөдөлсөн; машина хөдлөх;* **хөсөг хөдлөх** (ердийн хөсгөөр аян жинд явж эхлэх).

ХӨДӨЛШГҮЙ хөдөлбөргүй, хөдлөх аргагүй; *хөдлөшгүй бат.*

ХӨДӨГ а м ь т а н тагтаатай адилхан нэгэн зүйл шувуу.

ХӨДӨЛБӨРГҮЙ хөдлөшгүй, лавтайяа, магад; *хөдөлбөргүй үнэн.*

ХӨДӨЛГӨӨ юмны хөдлөх; *хөдөлгөө орох; хөдөлгөөтэй болох.*

ХӨДӨЛГӨӨГҮЙ 1. хөдлөхгүй, суурь тогтвор сайтай; *хөдөлгөөгүй сандал;* 2. хөдөлгөө муутай, удаан, назгай; *хөдөлгөөгүй янзын амьтан;* 3. төлөв томоотой, олон зан аашгүй, нэгэн зангаараа; *хөдөлгөөгүй сайн хүн гэж итгэж болно.*

ХӨДӨЛГӨӨН 1. материйн оршин ахуйн хэлбэр, материаллаг ертөнцийн тасралтгүй хөгжлийн явц; 2. нийгмийн тодорхой санал зорилго бүхий үйл явдал; *шинийг санаачлагчдын хөдөлгөөн; хувьсгалт хөдөлгөөн; энх тайвны төлөө хөдөлгөөн;* 3. алив хэсэг хүмүүс, юмны хөдлөх явдал; *гудамжны хөдөлгөөн; төв замын хөдөлгөөн.*

ХӨДӨЛГӨӨТЭЙ 1. хөдөлгөө бүхий, хөдөлгөө ихтэй; *хөдөлгөөтэй гудамж;* 2. ажилсаг, тогтвор муутай хөнгөн, залирхаг; *хөдөлгөөтэй залуу; харахад томоотой юм шиг атлаа сүрхий хөдөлгөөтэй хүн.*

ХӨДӨЛГӨХ хөдлөхөд хүрүүлэх, хөдөлгөөнтэй болгох, хөдөлгөө оруулах; **шороо хөдөлгөх** (арай чарай амьд амьдрах).

ХӨДӨЛГҮҮР 1. хөдөлгөдөг юм; *хөдөлгүүр оньс;* 2. аливаа энерги хүчнийг механик ажил болгон хувиргагч машина; *уурын хөдөлгүүр.*

ХӨДӨЛМӨР ажил: **ажил хөдөлмөр** х о р ш.; *хөдөлмөрт дуртай; хөдөлмөр бол нэр төрийн хэрэг мөн;* **биеийн хөдөлмөр** (бие махбодын хүчин чадалд тулгуурлан хийх ажил); **оюуны хөдөлмөр** (оюун ухаан, бодолд тулгуурлан хийх ажил); **хөдөлмөр өдөр** (нэгдлийн гишүүдийн хөдөлмөрийг бүртгэх нэгж); **хөдөлмөрийн дэвтэр** (ажилчин албан хаагчдад өгөх дэвтэр, засаг захиргааны байгууллагаас хийсэн ажил, ажилласан жил, шагнал урамшил, ажилд орох ба гарах, халагдах зэргийг уг дэвтэрт тэмдэглэнэ); **хөдөлмөрийн хүмүүжил** (нийгмийн тустай хөдөлмөрт хүүхэд багачуудыг дуртай болгох, хүндэтгэх, бас тэдэнд хөдөлмөрийн дадлага олгох хүмүүжил); **хөдөлмөрийн хууль** (ажилчин албан хаагчдын хөдөлмөрлөх эрх, үүргийн тухай хууль); **хөдөлмөрийн чадвар** (аливаа үйл ажлыг амжилттай хийж чадах нөхцөл, чадал); **хөдөлмөрийн сахилга бат** (ажиллах хөдөлмөрлөхөд чанд сахих дүрэм: *хөдөлмөрийн сахилга батыг сахих явдал бол иргэн бүрийн хүндэт үүрэг мөн);* **хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон** (үйлдвэр, хөдөө аж ахуй, соёл, шинжлэх ухааны салбар хийгээд улс нийгмийн үйл хэрэгт гавьяа байгуулагчдад шагнах одон тэмдэг).

ХӨДӨЛМӨРГҮЙ ажилгүй, сул зүгээр суудаг; *хөдөлмөргүй хүн-хүнсээр дутмаг; хөдөлмөргүй этгээд.*

ХӨДӨЛМӨРЛӨХ хөдөлмөр хийх, ажил хийх, ажиллах; *би найман цаг хөдөлмөрлөдөг; хөдөлмөрлөх чадал; хөдөлмөрлөх боломцоо.*

ХӨДӨЛМӨРЛҮҮЛЭХ хөдөлмөрлөхийн үйлдүүлэх хэв.

ХӨДӨЛМӨРЧ ажилч, ажилсаг; *хөдөлмөрч хичээнгүй хүн.*

ХӨДӨЛМӨРЧИН биеийн хүчээ үнэлж амьдрагч; *хөдөлмөрчин олон түмэн; хот хөдөөгийн хөдөлмөрчид; хөдөлмөрчин хүмүүсийн аж байдлыг сайжруулах.*

ХӨДӨӨ (Н) I 1. суурьшсан хот суурин буюу тариалангүй газар; **хөдөө гадаа** х о р ш.; *хөдөөний айл; хөдөө гэртээ харих; хөдөө орон нутаг; хот хөдөөгийн ялгавар; хөдөөний байдалтай танилцах; манайд хөдөөний хүн ирсэн;* **хөдөө аж ахуй** (газар тариалан, мал аж ахуй, ойн аж ахуй зэрэг зүйлээс бүрдэх, ардын аж ахуйн нэгэн салбар); **хөдөө гарах, хөдөө явах** (хот суурин газраас гадагш алс гарч явах); 2. нутагласан айл хүмүүсгүй ба гол уснаас агалга хээр газар; *хөдөө хээр; тал хөдөө, хөдөө талын билчээр;* **хөдөө газар** (а. ус намгаас зайдуу, уулнаас алсхан сэргэлэн газар; б. хотын биш, хөдөө аж ахуй эрхлэх газар).

ХӨДӨӨ II хөдөг шувуу.

ХӨДӨӨЛӨХ 1. хот суурин газраас хөдөө гарах, хөдөөний айл болох; *хотоос хөдөөлж гарах;* 2. айл өрхийн гол уснаас холдож хөдөө хээрт шилжиж нутаглах; *хөдөөлж буух;* 3. зарим амьтны орших газраас өөр газар шилжин орших; *бух хөдөөлөх; шувуу хөдөөлөх.*

ХӨДӨӨЛҮҮЛЭХ 1. хөдөөлөхийн үйлдүүлэх хэв; 2. малыг алсын билчээрт гаргах; *мал хөдөөлүүлж билчээх;* 3. хүүр оршуулах; *хүн хөдөөлүүлэх.*

ХӨДӨӨРХҮҮ хөдөөний байдалтай; *хөдөөрхүү газар; хөдөөрхүү айл.*

ХӨДӨӨРХӨХ хөдөөний байдал гаргах.

ХӨДӨӨШИХ хөдөөний шинжтэй болох.

ХӨДӨӨШРӨХ хот суурин газрын заншил байдлыг оорч хөдөөний байдалд орох.

ХӨДӨӨШРҮҮЛЭХ хөдөөшрөхийн үйлдүүлэх хэв.

ХӨДӨӨШҮҮЛЭХ хөдөөшихийн үйлдүүлэх хэв.

ХӨДӨС ХӨДСӨН 1. элдсэн нэхий арьсны баахан хуучирсны нь; *хөдсөн дээл; хөдсөн оймс;* 2. элдсэн нэхий арьсны год өөдөс; *хөдөс хярга ж ашиглах; хөдөс чанаж цавуу хийх.*

ХӨДХӨ ёс журам мэдэхгүй бүдүүлэг бядуу.

ХӨЕӨ I зарим амьтны хоолойн доод этгээдэд байдаг юм хум агуулах сав; *тахианы хөвө; хэнгэрүүгийн хөвө.*

ХӨЕӨ II зарим амьтны хучлага дэвсгэр буюу идшинд хэрэглэхээр хураасан хадгалсан юм; *оготны хөвө; хөвө хураах.*

ХӨЕӨЛӨХ хөвө хураах.

ХӨЖ үхэр тэмээг босгох, явуулахад зандах аялга; *хөж хөж!*

ХӨЗӨР дөрвөн зүйлийн зураг дүрстэй цаас, ахлах дүүлэх тоо тэмдэгтэй тусбүр адил тоотой, олон янзаар наадаж болдог нэгэн зүйл тоглоом; **хөзөр тавих** (хөзрөөр наадах).

ХӨЗӨРДӨХ хөзрөөр наадах.

ХӨЗӨРДҮҮЛЭХ хөзөрдөхийн үйлдүүлэх хэв.

ХӨЗӨРЧ хөзрөөр наадахдаа чадамгай.

ХӨЛ 1. амьтны газар гишгэх мөчийн нэр; *баруун хөл; урд хөл; хойт хөл; хөлийн ороолт;* **хиймэл хөл** (хөлгүй хүнд хийж тохируулсан хөл); **модон хөл** (гутлын уланд уяж өндөрлөн явахад зориулан тохируулсан мод); **хөл нүцгэн** (гутал оймсгүй); **хөлд орох** (а. нялх амьтны хөл дээрээ тэнцэж явах болох; б. гадуур дотуур явах дургүй байсан хүн, явахыг дурлах болох); **хөлөө олох** (а. алдсан хөлийн алхааг зөвтгөж нийлэн гишгэх; б. хөлжих, бэлтэй болох); **хөлөө алдах** (а. нийлж явсан хөлөө сольж, буруутах; б. хөл алдах, бэл алдах); **хөлөө татах** (а. гадуур дотуур явахаа багасгаж цөөвчлөх; б. жийсэн хөлөө хурааж атирах); **хөл орох** (а. гишгэн явж чадах болох; б. суумгай зантай хүн, явамхай болох); **хөл хумих** (а. гадуур явахаа татах, багасгах; б. гэрээс гарахгүй суух); **хөл бохирох** (өрөөсөн хөлөөр сөгдөх); **хөл бохирохгүй** (огт амрахгүй); **хөл унаа** (унаж яваа уналга); **хөл машина** (хөлөөр гишгэж оёдог оёдлын машина): **хөл ооль** (босоо зогсож цавчих ооль); **хөл уур** (тариа зэргийн юмыг гишгэж нүдэхээр тохируулж хийсэн нэгэн зүйл уур); **хөл бөмбөг** (хоёр баг болж наадах биеийн тамирын тоглоом, бөмбөгийг өшиглөн хөөж эсэргүүцэл этгээдийн хаалганд оруулан наадна); **хөл бөмбөгчид** (хөл бөмбөг наадагчид, хөл бөмбөгийн баг); **хөл хянагч, хөлийн түшмэл** (бөх барилдах тэмцээний маргаан, будлианыг шүүн шийтгэгч); **хөл залгах** (явган хүний уналгатай болох); **хөл хорих, хөл цээрлэх** (айл гэр буюу нутаг газарт ямар нэгэн цээрлэлтэй зүйл гарсан учир гаднын хүнийг оруулахгүй хориг тэмдэг тавих); **хөл хэрэх** (ямар нэгэн хэргээр нутаг орноос гарч тэнүүчлэн явах); **хөл хүнд** (а. бие жирэмсэн: *хөл хүнд болох;* б. удаан назгай, хүнд хөлтэй ч гэдэг); **хөл хүндрэх** (а. жирэмсэн болох; б. явах хэсэх дур болих); **хөлд нь суух** (завшаан эрж бусдад хуурамч ааш бааш гаргах); **хөл нь дөрөөнд хүрэх** (нас биенд хүрэх, биеэ дааж чадах болох; *гар нь ганзганд, хөл нь дөрөөнд);* **хөл нь газар хүрэхгүй** (маш их хөөр болж явахы нь); **хөл хөнгөрөх** (а. баяр хөөр болж сэтгэл нь хөхөх; б. явах хөдлөх дур зориг орох); **хүнд хөлтэй** (аажуу, удаан назгай); **хөнгөн хөлтэй** (түргэч, хөдөлгөөтэй); **хөл дээрээ зогсох, хөл дээрээ гарах, хөл дээрээ босох** (биеэ дааж ажиллаж амьдран чадах болох); **хөл алдах** (а. ус гатлахад хөл газар хүрэхгүй болж хөвөх; *усанд хөл алдах;* б. худалдаа арилжаа хийгчид, ашиг хонжвор олох байтугай, бэл хөрөнгөдөө халдаж сүйрэх; *хөл алдсан панзчин;* в. олон буюу их юмны дотор орсны улмаас аль ч учраа олохгүй элмэрэх, нүд алдах ч гэдэг; *зах дээр өчөөд хөл алдахад хүрэв);* 2. ширээ сандал, тогоо зэрэг юмны гулгуур; *сандлын хөл;* **зургийн аппаратны хөл** (зураг авах үед аппаратыг хөдөлгөөгүй болгоход хэрэглэх тулгуур); **бууны хөл** (буудах үед бууг хөдөлгөөгүй болгох тулгуур); **гүүрний хөл** (гүүрийн тулгуур баганууд); 3. ш и л ж с э н юмны шувтрах үзүүр, адаг; **модны хөл** (хушуурч ургасан ой модны шувтрах үзүү-

рийн орчин газар); **уулын хөл** (уулын шувтрага бэлийн орчин газар); **усны хөл** (гол горхины шувтрага адаг); **буцны хөл, хотны хөл** (хот буцны адаг зах); 4. ш и л ж с э н үймээн, хөдөлгөөн, бэл, сурвалж; **хөл хөдлөх, хөл болох** (а. дайн дажин, үймээн түйвээн үүсч дэгдэх; б. үйл үйлдвэр хийхийн тул ихэд бэлтгэж ихээхэн хүч хөдөлмөр гаргах; *тэднийх шинэ гэр барих гэж тун их хөл хөдөлж байна; наадамд очих гэж хөл хөдөлж байна);* **хөл үймээн, хөл хөлсөөн** (а. хөл шуугиан их; б. үймээн самуун); **хөл татрах** (олны явах зорчих нь цөөрөх, намжих); **хөл тасрах** (олны явах зорчих хөл хөдөлгөөн зогсох): **гудамжны хөл** (а. гудамжны адаг шувтрага; б. хөл хөдөлгөөн их); **хөл ихтэй** (а. бэл хөрөнгө ихтэй; б. хөл үймээн ихтэй); **хөл багатай** (а. бэл хөрөнгө тун бага; б. орох гарах хүн цөөн); **хөл муутай** (а. бэл хөрөнгө багатай: б. чадал чинээ ядуу дорой; в. хөл нь доголон буюу бэртэнгэтэй); **хөл сайтай** (а. бэл хөрөнгө ихтэй; б. чадал чинээ ихтэй; в. шөрмөс булчин сайтай); **хөлтэй худалдаа** (юм бүхэнтэй буюу их юмтай худалдаа); **хөл хийх** (а. ямар нэгэн юмаар бэл хөрөнгө болгох; *мянган төгрөгөөр хөл хийж байгуулсан касс;* б. юмны газар тулах тулгуур хийх): **хөлий нь олох** (ул үндсийг мэдэх, учир иший нь олох); **хөлтэй ус** (а. ундрага сайтай, их устай; б. хөл уналгаар гаталж болох ус); **хөл нэгтэй** (үйл явдал нь эрхбиш холбогдол нэгтэй); ☆ **малын хөл** (мал тус бүрд таацуулан бодож ногдуулсан ногдол зүйл; *малын хөлийн татвар);* **эмийн хөл** (эмийн хаяг пайз). ᠬᠥᠯ

ХӨЛБӨР тэрэг чарганд мал хөллөх газар. ᠬᠥᠯᠪᠥᠷ

ХӨЛБӨРГӨН 1. хөнтөргөн, хазгай; 2. урвамтгай, булталхай, хөвсөргөн. ᠬᠥᠯᠪᠥᠷᠭᠥᠨ

ХӨЛБӨРӨХ 1. өнхрөх, юмны орчин эргэх; **өнхрөх хөлбөрөх** х о р ш.; 2. биеэсээ зайлуулах, булталх; *хөлбөрч унах; ачаа хөлбөрөх;* 3. үйл ажилд тогтворгүй урваж няцах; **урвах хөлбөрөх** х о р ш.; *ямраар хөлбөрөхийг бүү мэд.* ᠬᠥᠯᠪᠥᠷᠥᠬ

ХӨЛБӨРҮҮ 1. хэлбэрүү, юмны зохих хэвээс хазгай, хөнтөргөн; 2. хөлбөргөн зантай. ᠬᠥᠯᠪᠥᠷᠦᠦ

ХӨЛБӨРҮҮЛЭХ хөлбөрөхийн үйлдүүлэх хэв. ᠬᠥᠯᠪᠥᠷᠦᠦᠯᠡᠬᠦ

ХӨЛГҮЙ 1. хөл байхгүй, хөл муутай; *хөлгүй морь;* 2. бэл хөрөнгө багатай, муутай; **хөлгүй айл** (а. хөл үймээн багатай; б. хөрөнгө юм багатай); 3. суурь багатай, суурь муутай; *хөлгүй ширээ;* 4. гүнзгий, их; *хөлгүй далай;* **хөлгүй ус** (а. ундрага муутай, бага устай; б. хөл уналгаар гаталж болохгүй гүнзгий их ус). ᠬᠥᠯᠭᠦᠢ

ХӨЛДМӨЛ 1. хөлдсөн юм; 2. хөлдөөсөн амтлаг идээ; *сүүний хөлдмөл; зэдгэний хөлдмөл.* ᠬᠥᠯᠳᠮᠥᠯ

ХӨЛДӨӨХ хөлдөхийн үйлдүүлэх хэв; *хөлөө хөлдөөх; сүү хөлдөөх.* ᠬᠥᠯᠳᠥᠥᠬ

ХӨЛДӨСХИЙХ баахан хөлдөх. ᠬᠥᠯᠳᠥᠰᠬᠢᠶᠬ

ХӨЛДӨХ I хүйтэнд юм хумны царцаж мөс буюу мөс мэт болох; *ус хөлдөх; бие махбод хөлдөх; хөлдөх гэм.* ᠬᠥᠯᠳᠥᠬ

ХӨЛДӨХ II эсэргүүцэл этгээдийн хөлөөс шүүрэн барих.

ХӨЛДҮҮ хүйтэнд хөлдөж хатуу болсон юм; *хөлдүү мах; хөлдүү сүү; хөлдүү цэвдэг; хөлдүү түүхий эд.* ᠬᠥᠯᠳᠦᠦ

ХӨЛДҮҮВТЭР хөлдүүшиг, баахан хөлдүү ᠬᠥᠯᠳᠦᠦᠸᠲᠡᠷ

ХӨЛДҮҮДЭХ хэтэрхий хөлдүү болох. ᠬᠥᠯᠳᠦᠦᠳᠡᠬ

ХӨЛДҮҮЛЭХ хөлдөхийн үйлдүүлэх хэв. ᠬᠥᠯᠳᠦᠦᠯᠡᠬ

ХӨЛЖИХ I уналгагүй хүний уналгатай болох. ᠬᠥᠯᠵᠢᠬ

ХӨЛЖИХ II бэл хөрөнгө ихтэй, юмтай болох.

ХӨЛЖИХ III хөлтэй, тулгууртай болох.

ХӨЛЖҮҮЛЭХ хөлжихийн үйлдүүлэх хэв, хөлжихөд хүргүүлэх. ᠬᠥᠯᠵᠦᠦᠯᠡᠬ

ХӨЛЛӨГӨӨ тэрэг чарганд оруулах малын гоног хэрэглэл; хөллөө ч гэдэг. ᠬᠥᠯᠯᠥᠭᠡᠡ

ХӨЛЛӨХ I тэрэг чарганд мал оруулж тоног хөллөөг тохируулан торгох; *морь тэрэг хөллөх.* ᠬᠥᠯᠯᠥᠬ

ХӨЛЛӨХ II ус татарч хөлөөр гатлан гарч болмоор болох; *ус хөллөх.* ᠬᠥᠯᠯᠥᠬ

ХӨЛЛӨХ III хөл хийх, юмны хөлийг тулгуурлан тогтоох, суурилах; *хөллөж барилдах; буу хөллөх.* ᠬᠥᠯᠯᠥᠬ

ХӨЛЛҮҮЛЭХ хөллөхийн үйлдүүлэх хэв. ᠬᠥᠯᠯᠦᠦᠯᠡᠬ

ХӨЛМӨГ I усны дээгүүр тогтсон буюу дор нь тунасан хөвөн мэт ногоовтор өнгөтэй юм; *усны хөлмөг; хөлмөг тогтох.* ᠬᠥᠯᠮᠥᠭ

ХӨЛМӨГ II х у у ч и р с а н хатан хүний ёслолд нөмрөх нэгэн зүйл хээнцэр хувцас; *хөлмөгтэй хатан үзэв.*

ХӨЛӨГ I далай мөрөн усны онгоц; *хөлөг онгоц.*

ХӨЛӨГ II шатар, мигмэн, буга, бух, жирэг зэрэг тоглоомын өрж наадах хүснэг зураг бүхий тавиур.

ХӨЛӨГ III 1. унах эдлэх морь; *хөлгийн сайныг унан байж мэддэг, хүний сайныг ханилан байж мэддэг* с э ц э н үг; *хөлөг морины хурд, хүдэр биеийн чадал мэднэ;* 2. хүндэтгэвэл зохих хүний уналга.

ХӨЛӨГ IV баатар; *хөлөг баатар.*

ХӨЛӨГЛӨГ сайн морь.

ХӨЛӨГЛӨХ эрхэм хүмүүсийн морь унаа унах; *морь хөлөглөн явав.*

ХӨЛӨГЧИН хар толботой цагаан морь.

ХӨЛӨЛБӨР тэрэг чарга зэргийн мал хөллөх хэрэглэл.

ХӨЛӨРГӨХ хөлс гаргах, хөлрөхөд хүргүүлэх; *морь хөлөргөх; хөлөргөх эм.*

ХӨЛӨРХҮҮ хөл ихтэй, хөл олонтой, хүн олон цугладаг; *хөлөрхүү айл; хөлөрхүү хот зээл.*

ХӨЛӨХ хөллөх.

ХӨЛРӨМТГИЙ их хөлөрдөг.

ХӨЛРӨХ I хөлс гарах; *би эм уугаад ихэд хөлрөв.*

ХӨЛРӨХ II хүйтэн, хөлдүү царцуу юмны халж хайлах маяг гарч эхлэх; *мөс хөлрөх; цас хөлрөх; тогоо хөлрөх.*

ХӨЛС I 1. хүн амьтны халуунцах, зүдрэх зэрэгт арьсны булчирхайгаас ялгаран гарах шингэн; *биений хөлс;* **хөлсний булчирхай** (хөлс ялгаруулан гаргах булчирхай): **хөлс батгах, хөлс цутгах** (ихэд хөлрөх); **хөлс цохих,** хөлс **сэвэх** (гарсан хөлсийг салхи цохих); **хөлс сэвхийх** (а. амьтны хөлөрсөн хөлс намдаж арилах; б. ажил хөдөлмөрт зүтгэж байгаад түр амсхийх); 2. мөнхүү шингэн бусад юманд наалдаж нэвтэрсний нь; *тохмын хөлс.*

ХӨЛС II хөдөлмөрийн үнэ буюу мал эдлэл зэргийг эдлүүлсний үнэд авах ацаг юм; **ацаг хөлс, үнэ хөлс, өртөг хөлс, цалин хөлс, шан хөлс** х о р ш.; *байшингийн хөлс; морины хөлс; ажлын хөлс; хөлсөөр хэрэглүүлэх.*

ХӨЛС III мөнгө зэргийн юмыг агсан авч, түүнийг хэрэглэсний төлөөс болгон өгөх хүү; ашиг; **хүү хөлс, үржил хөлс** х о р ш.

ХӨЛСГҮЙ ашиг хөлс өгч авахгүй; *хөлсгүй унаа хэрэглэх; хөлсгүй ажил хийхгүй; хөлсгүй орон сууц.*

ХӨЛСЛӨГДӨХ хөлслөхийн үйлдэгдэх хэв.

ХӨЛСЛӨГЧ хөлсөөр хэрэглэгч; *хөлслөгч этгээд.*

ХӨЛСЛӨХ I 1. хөлөргөх, хөлрүүлэх; *хөлсөлж эмчлэх;* 2. морь малыг уях хагсаахад хөлсийг гаргаж засах; *уралдааны морь таралж хөлслөх;* 3. морины хөлсийг хусуураар хусч арилгах; *морио хөлслөөд тавь.*

ХӨЛСЛӨХ II хөлс ашиг авч өгч эд юм эдлэх, эдлүүлэх; *машина хөлслөх; унаа хөлслөх; хүчээ хөлслөх.*

ХӨЛСЛӨХ III мөнгө алтыг бусдад зээлүүлж ,хүү үржүүлэн язуурын тоо хэмжээнээс нэмүүлэн авч хүүлэх; *мөнгө хөлслөх.*

ХӨЛСЛҮҮЛЭХ 1. хөлслөхийн үйлдүүлэх хэв; 2. хөлслөгдөх.

ХӨЛСӨВЧ 1. хөлс хамгаалах дотуур хувцас; 2. тохмын жийрэг.

ХӨЛСӨГ хөл үймээн ихтэй, хөлөрхүү.

ХӨЛСӨӨН хөл үймээн; **хөл хөлсөөн** х о р ш..

ХӨЛСӨӨХ хөлсөх II-ын үйлдүүлэх хэв, хөлсөхөд хүргүүлэх.

ХӨЛСӨХ I хүйтний цагт хоёр хүн харилцан хөлөө зөрүүлж хучлагаа нэгтгэн хэвтэх, унтах; *хөлсөж хэвтэх.*

ХӨЛСӨХ II 1. хөл үймээн их болох; *хөлсөн сэлгүүцэх;* 2. өвчтэй хүмүүс буюу хүүхэд багачуудын бие гаднын хөл үймээнээс шалтгаалж ая тавгүй болох; *хүүхэд хөлссөн юм үү, ер унтсангүй.*

ХӨЛТРӨГ монгол гэрийн дээврийн гадуур бөс зэрэг эдээр хийж тооныг тойруулсан бөгөөд дөрвөн зүгт ханын толгой хүртэл нарийвтар урт хушуу гарган хийсэн янз чимэг, хөлт өрх, өрхний хөл ч гэдэг.

ХӨЛТЭЙ 1. хөл бүхий юм; 2. олон хүн явах зорчих, үймээн шуугиан ихтэй газар; *хөлтэй айл; хөлтэй гудамж; энэ өдөр зах дээр хөлтэй байна.*

ХӨЛХ хүн амьтны нүдэнд тогтсон цагаавтар юм, үүл ч гэдэг.

ХӨЛХӨГ усны чулууг бүрэн тогтсон наалдангир юм, хигдэр ч гэнэ.

ХӨЛХӨЛДӨХ хөлхөхийн үйлдэлдэх хэв.

ХӨЛХӨХ хүний нааш цааш олонт явалцах; *дэмий хөлхөх хэрэггүй; битгий хөлхөөд байгаач.*

ХӨЛХҮҮЛЭХ хөлхөхийн үйлдүүлэх хэв.

ХӨЛЧИХ I хүйтний цагт гараа галд ээж дулаацуулах; *галд гараа хөлчих.*

ХӨЛЧИХ II хадсан тариаг юүжилж, иштэй нь баглаа баглаагаар босгон тавьж хатаах; *тариа хөлчих.*

ХӨЛЧЛӨГ хөлчих үйлийн нэр.

ХӨЛЧӨӨХ хөлчихөд хүргүүлэх, хөлчүүлэх.

ХӨЛЧҮҮ согтуу; **хөлчүү согтуу** хорш..

ХӨЛЧҮҮЛЭХ хөлчихийн үйлдүүлэх хэв.

ХӨЛЧҮҮРХЭХ хөлчүү зан байдал гаргах.

ХӨЛЧҮҮРЭХ архи дарс баахан ууж согтуурах.

ХӨМ төлөөс дээш насны бод малын элдэж зөөлрүүлсэн шир; *хөм дэвсгэр; хөм уут.*

ХӨМӨЛ ургамал сонгинын төрлийн ургамлын нэг зүйл: **таана хөмөл, гогод хөмөл, мангир хөмөл** хорш..

ХӨМӨЛДРӨГ эмээлийг хойш нь явуулахгүйн тул эмээлийн өмнөд хавтаснаас торгож, морь малын омруунд хийх нэгэн зүйл хэрэглэл.

ХӨМӨЛДРӨГЛӨХ морь малд хөмөлдрөг хийх.

ХӨМӨЛДРӨГЛҮҮЛЭХ хөмөлдрөглөхийн үйлдүүлэх хэв.

ХӨМРӨГ I амьтан хэлбэр нь хүний хумсны төсөөтэй, тал бөөрөнхий, элгэн этгээд хонхор, шаравтар ухаа өнгөтэй нэг зүйл хорхой.

ХӨМРӨГ II хөвхөн хэлбэртэйгээр хийсэн бөгөөд хөмрүүлэн тавих, орны буюу суудлын давшуурга; *хөмрөг ор; хөмрөг давшуурга.*

ХӨМРӨГ (ӨН) III улсын сангийн хөрөнгө юмыг хурааж хадгалах газар; **сан хөмрөг, хүү хөмрөг** хорш.; *номын сангийн хөмрөгөнд байгаа чухал номууд.*

ХӨМРӨГЧ улсын сангийн хөрөнгө юмыг эрхлэн хадгалах хүн.

ХӨМРӨӨТЭЙ хөмөрч тавьсан; *хөмрөөтэй түмпэн.*

ХӨМРӨХ 1. аливаа сав суулга зэргийн юмыг түрүүлэг нь хандуулах; *тогоо хөмрөх;* 2. юмыг уруу нь харуулах, хөнтрөх, доош нь харуулах.

ХӨМРҮҮ: хөмрүү цэцэг ургамал хөмөрсөн цомоогийн адил хэлбэртэй, цэцэг нь хөнтрөн ургадаг нэгэн зүйл ургамал.

ХӨМРҮҮЛ хөмөрдөг юм; *хөмрүүл тавиг.*

ХӨМРҮҮЛЭХ 1. хөмрөхийн үйлдүүлэх хэв; 2. хөмрөгдөх.

ХӨМСӨГ I аньсганы дээгүүр хөндлөн ургасан үс; **хөмсөг зангидах** (хилэгнэж бусдыг муухайгаар харах, ярвайх).

ХӨМСӨГ II 1. сав суулга, орон барилга зэрэгт өнгийлгөж хийсэн янз; *ширээний хөмсөг; цонхны хөмсөг;* 2. уул хадны өнгийсөн ирмэг; *уулын хөмсөг; хадны хөмсөг.*

ХӨМҮҮЖИГЧ хөмүүжил авсан хүн; хөмүүжил авч буй хүн.

ХӨМҮҮЖИЛ нийгмийн амьдралд илрэх зан чанар; *хөмүүжил сайтай ;хөмүүжил муутай; хөмүүжил олох;* **коммунист хөмүүжил** (хүмүүсийн ухамсар дахь хуучин нийгмийн үлдэгдлийг бүрэн устгаж, бүх хөдөлмөрчдийг эв хамтын бүтээн байгуулах үйл хэрэгт идэвхтэй оролцогчид болгох чухал арга).

ХӨМҮҮЖИЛГҮЙ хөмүүжиж чадаагүй, хөмүүжээгүй.

ХӨМҮҮЖИЛТЭЙ хөмүүжиж чадсан, хөмүүжил сайтай.

ХӨМҮҮЖИХ хүн болох, хөмүүжил олох, мэдлэг боловсрол, мэрэгжил чадвар нь дээшлэх, сайжрах; *сургуульд сурч хөмүүжих; эцэг эхийн асрамж сургамжид хөмүүжих; гэм бурууг ухамсарлан засарч хүмүүжих.*

ХӨМҮҮЖЛЭГ хөмүүжил.

ХӨМҮҮЖРЭЛ хөмүүжирсэн нь, хөмүүжил.

ХӨМҮҮЖРЭХ хөмүүжих, хөмүүжил олох.

ХӨМҮҮЖҮҮЛЭГЧ бусдыг удирдан залж, зөв сайны зүг хандуулах буюу асран харгалзах хүн; *цэцэрлэгийн хүүхэд хүмүүжүүлэгч.*

ХӨМҮҮЖҮҮЛЭХ хөмүүжихийн үйлдүүлэх хэв, хөмүүжил олгох; *багачуудыг асран хөмүүжүүлэх газар.*

ХӨМҮҮН I хүн.

ХӨМҮҮН II хүний хамрын дорхи, дээд уруулын дундах говил.

ХӨМХИЙ доод уруул; **хөмхийгөө зуух** (доод уруулаа дотогш болгон зуух, шазуур зуух ч гэдэг).

ХӨНГӨВТӨР хөнгөншиг, баахан хөнгөн.

ХӨНГӨВЧЛӨЛ хөнгөвчлөх үйлийн нэр; *хөнгөвчлөл үзүүлэх.*

ХӨНГӨВЧЛӨХ юмны үлэмжээс цөөтгөх, бэрхээс хялбар болгох, хүндээс хасах; *ажлаас хөнгөвчлөх; албан татвары нь хөнгөвчлөх; ялыг хөнгөвчлөх.*

ХӨНГӨВЧЛҮҮЛЭХ 1. хөнгөвчлөхийн үйлдүүлэх хэв; 2. хөнгөвчлөгдөх.

ХӨНГӨДӨХ 1. хэтэрхий хөнгөн болох; 2. юмыг болгоомжлохгүй хөнгөнд үзэх; *дэндүү хөнгөдөх хүн байгаа юм.*

ХӨНГӨДҮҮЛЭХ хөнгөдөхийн үйлдүүлэх хэв, хөнгөн болгох.

ХӨНГӨЖИХ 1. хөнгөн болох; 2. ш и л ж с э н жирэмсэн эмэгтэйчүүдийн төрөх.

ХӨНГӨЖҮҮЛЭХ хөнгөжихийн үйлдүүлэх хэв.

ХӨНГӨЛӨЛТ хөнгөлөх үйлийн нэр, хөнгөлөх үйлийн явц; *хөнгөлөлт үзүүлэх ;хөнгөлөлт гуйх.*

ХӨНГӨЛӨХ I мал адгуусыг агтлах, засах; *хурга хөнгөлөх; ишиг хөнгөлөх.*

ХӨНГӨЛӨХ II 1. хөнгөн болгох, хөнгөтгөх; *гэр хөнгөлөх; ачаа хөнгөлөх; алба хөнгөлөх; ял хөнгөлөх;* 2. ш и л ж с э н хүн амьтныг зүй ёсоор тоомсорлохгүй хөнгөнд үзэх.

ХӨНГӨЛҮҮЛЭХ 1. хөнгөлөхийн үйлдүүлэх хэв; 2. хөнгөлөгдөх.

ХӨНГӨМСӨГ 1. биеийг доор болгож найр тавих зан ааль; *хөнгөмсөг зан; хөнгөмсөг байдал;* 2. хөнгөн хийсвэр гэнэн байдал; *тэр ажлыг ч хөнгөмсөг хүн хийж чадахгүй.*

ХӨНГӨМСӨГЛӨХ хөнгөмсөг зан байдал гаргах.

ХӨНГӨН 1. хүнд гэдгийн эсрэг утга, чанар хүнд биш юм; **хүнд хөнгөн** х о р ш.; *өргөх тээхэд хөнгөн ачаа; хөнгөн дээлээ өмс;* 2. гавшгай, шуурхай, ялгум хөдөлгөөнтэй; **хөнгөн гавшгай, хөнгөн шингэн, хөнгөн шуурхай** х о р ш.; *хөнгөн хөдөлгөөтэй хүн; хөнгөн явдалтай морь; сурхий хөнгөн шингэн өвгөн;* 3. гэнэн, наагуур, хийсвэр, хуумгай; **хөнгөн хуумгай, хөнгөн хийсвэр** х о р ш.; *гэнэн хөнгөн зантай хүн; чи дэндүү наагуур хөнгөн бодож болохгүй;* **хүндээ хөнгөнөөс өгөх** (хүндлэгдвэл зохих атлаа хийсвэр, гэнэн зан байдал гаргах); 4. хатуу чанга биш, зөөлөн; *хөнгөн шийтгэл ногдуулжээ; хөнгөн ялын зүйл; хөнгөн алба үзэж явна бид; хөнгөн жанчих;* **хөнгөн хоол** (шингэхдээ хялбар, чанартай хоол); **хөнгөн тэрэг** (суудлын тэрэг): **хөнгөн цагаан** (химийн махбод, мөнгөлөг цагаан бөгөөд хөнгөн, давтахад хялбар төмөрлөг); **хөнгөн пулемёт** (нэг хүн авч явж болох авсаар пулемёт); **хөнгөн шингэн** (авсаархан бага юмтай; *манайх зусланд хөнгөн шингэн гарав).*

ХӨНГӨНДҮҮ 1. баахан хөнгөн шиг; *хөнгөндүү зантай хүн;* 2. зөөлөн, сүртэй биш.

ХӨНГӨР 1. юмны битүү чийгтэй газар байснаас үүсч тогтсон хөгц мэт юм; 2. юманд битүү чийгээс болж тогтсон цан; *хөнгөр цохих;* **хөнгөр дэлсэх** (а. идээ цагааны зэрэг юм, битүү чийгтэх мэтээс хувирч гадуур нь хөгц мэт юм тогтох; б. юмны битүү чийгтэх мэтээр цантах).

ХӨНГӨРӨХ I юмны хөнгөн болох.

ХӨНГӨРӨХ II хүний нярайлах, хөнгөжих.

ХӨНГӨРТӨХ юманд хөнгөр тогтох.

ХӨНГӨРҮҮЛЭХ хөнгөрөхийн үйлдүүлэх хэв, хөнгөн болгох.

ХӨНГӨСГӨХ хөнгөтгөх.

ХӨНГӨСӨХ хөнгөтөх.

ХӨНГӨТГӨХ аливаа юмны ихийг багатгах, хүлцийг хөнгөн болгох, олныг цөөтгөх, хөнгөсгөх; *ногдлыг хөнгөтгөх; хөнгөтгөх шалтгаан нь... албан үүргийг нь хөнгөтгөх.*

ХӨНГӨТГҮҮЛЭХ 1. хөнгөтгөхийн үйлдүүлэх хэв; 2. хөнгөтгөгдөх.

ХӨНГӨТӨХ улмаар хөнгөн болох.

ХӨНГӨХӨН нэн хөнгөн, нилээд хөнгөн.

ХӨНДИЙ 1. юмны цул биш, дүүрэн биш, дотроо ихээхэн хий зайтай, хоосон, ханхай; *дотооддоо хөндий юм; хөндий ханхай гэрэл; авдраа газраас хөндий тавьл хөндий гоймонг*

хөндий дархи; **цээжний хөндий** (цээжин бие дахь зай; *цээжний хөндийн мэс заслал);* **хөндий цээж** (юм мэдэхгүй мөртөө мэдэмхий зантай, бардам дээрэнгүй; *хөндий цээжнээс цаашгүй амьтан);* 2. хоёр хэсэг уул нуруу мэтийн хоорондуур үргэлжлэн алсалсан тэгш тавиу газар; *уулын хөндий;* 3. хоёр голын хоорондох тэгш тавиу газар; *голын хөндий;* 4. хол, зайдуу; *түүнээс хөндий явах хэрэгтэй; хөндий бай!*

ХӨНДИЙВТӨР хөндийшиг, баахан хөндий.

ХӨНДИЙЛӨХ 1. хөндий болгох; *гэрийн шал хөндийлөх; юмаа дороос нь хөндийлж хураах хэрэгтэй;* 2. шилжсэн дотор талаас нь аажим аажмаар хорлох; *дотроос нь хөндийлөх.*

ХӨНДИЙЛҮҮЛЭХ хөндийлөхийн үйлдүүлэх хэв.

ХӨНДИЙРӨХ хөндий болох, холдох, завсар зай гарах; *ижилдсэн ханилсан хоёр хоорондоо улам хөндийрсөөр байв; энэ бол эцэг эхээсээ хөндийрч үзээгүй хүүхэд; байшингийн шавар хөндийрөх.*

ХӨНДИЙРҮҮЛЭХ хөндийрөхийн үйлдүүлэх хэв, хөндийрөхөд хүргүүлэх.

ХӨНДИЙХӨН хөндийшиг, баахан хөндий.

ХӨНДЛӨВЧ хөндөлдүүлэн хийсэн юм; *хөндлөвч мод; хөндлөвч ялуу.*

ХӨНДЛӨН I гулд гэдгийн эсрэг утга, юмны туус дагуу биш, нөгөө тийш буюу өргөн тийш; **хөндлөн гулд** хорш.; *энэ даавууг хөндлөн цуулж хий! зам хөндлөн гарахдаа машина мэдэж яваарай; гол дээр банз хөндлөн тавьсан байв.*

ХӨНДЛӨН II хоёр эсэргүүцлийн аль ч биш, гуравдугаар этгээд буюу хажуугийн этгээд; *хөндлөнгийн хүн; хөндлөн этгээд; хөндлөнгийн гэрч; хөндлөнгөөс оролцох гэсний хэрэг юун; хөндлөнгийн үг; хөндлөнгийн хэл ам; хөндлөнгийн ажил;* **хөндлөн бишгүүр** (лимбэний нэг зүйл); **хөндлөн зан** (этгээд гажуу зан); **хөндлөн ярих** (хэлэлцэж байгаа зүйлд хамаарч холбогдохгүй буруу зөрүү ярих).

ХӨНДӨГДӨХ 1. хөндөхийн үйлдэгдэх хэв; 2. хөндүүлэх.

ХӨНДӨЛДӨХ 1. юмны туус дагуу биш, хөндлөн тийш болох, хэвтэх; *зам дээр мод хөндөлдөн хэвтэв;* 2. халхлах хөшөөлөх мэтээр саад хийх, зогсоох; *зам сувийг боогдуулан хөндөлдөх; хөндөлдөж зогсох; хөндөлдөж өмөөрөх.*

ХӨНДӨЛДҮҮЛЭХ хөндөлдөхийн үйлдүүлэх хэв.

ХӨНДӨӨ шагаагаар бөг чэг нясалж тогло-ход орхисон шагаа түшилдэн туссаныг нь; *хөндөөтэй шагаа нясалж болохгүй, хөндөөгий нь гарга.*

ХӨНДӨХ юмыг хөдөлгөх, хүрэлцэх, өдөх; *эмээг өвчтэй газар хөндөх; эрүүл атар газар хөндөх; шагаа хөндөх;* **үг хөндөж асуух** (үг сэдэж асуух).

ХӨНДҮҮЛЭХ 1. хөндөхийн үйлдүүлэх хэв; 2. хөндөгдөх

ХӨНДҮҮР бие махбодын өвчин эвэршил бүхий эмзэг бөгөөд хүрэлцвэл хөндөгдөх газар; *хөндүүр газрыг олох; тэнд чинь гар хүрч болохгүй, хөндүүр шүү; миний эрхий хуруугны хөндүүр нь арилахгүй юм.*

ХӨНДҮҮРЛЭХ хөндүүр өвчин бүхий газар, хөдлөх хүрэлцэхийн зэрэгт эмзэглэх; *хоолой хөндүүрлэх.*

ХӨНДҮҮРХИЙ хөндүүр.

ХӨНЖИЛ нөмрөх хучихад хэрэглэх нэгэн зүйл хучлага; *тэрлэг хөнжил; хөвөнтэй хөнжил; нэхий хөнжил.*

ХӨНӨГ 1. шингэн юм агуулах нэг зүйл сав; **хөхүүр хөнөг** хорш.; *усны хөнөг; сааль сүүний хөнөг;* 2. цахиур бууны дарь агуулах эвэр сав; *хөнөгтэй дарь;* 3. үйсээр хийсэн хувин; *үйсэн хөнөг.*

ХӨНӨӨГДӨХ хөнөөхийн үйлдэгдэх хэв.

ХӨНӨӨЛ хөнөөх үйлийн нэр, хорлол; **хор хөнөөл** хорш.; *биед хөнөөлтэй ажил; чоно-малд хөнөөлтэй; хөнөөлт араатан; хөнөөлтэй муу хүн.*

ХӨНӨӨЛГӨХ 1. хөнөөхийн үйлдүүлэх хэв; 2. хөнөөгдөх.

ХӨНӨӨЛГҮЙ харшлал хорлолгүй; *хөнөөлгүй хүн; хөнөөлгүй амьтан.*

ХӨНӨӨЛТЭЙ хөнөөл бүхий, харшлалтай, хорлолтой; *чоно-хөнөөлтэй амьтан; оготнобилчээрт хөнөөлтэй.*

ХӨНӨӨЛЦӨХ хөнөөхийн үйлдэлцэх хэв.

ХӨНӨӨХ хөнөөл хүргэх, хор хүргэх, хорлох; **хорлох хөнөөх** хорш.; *гэмгүй амьтныг хөнөөх ямар хэрэг байна? хөнөөх сэтгэл бүү үүсгэ.*

ХӨНТГӨР хоёр хөмсөгний хоорондох зай.

ХӨНТИЙЛГӨХ хөмсөг зангидах; *хөмсөг хөнтийлгөх.*

ХӨНТӨРГӨН нэгэн этгээд өндөрхөн, нөгөө этгээд нь нам бөгөөд зохих хэм жишээд тохирохгүй болсныг нь, хэлбүү, өөс; *хөнтөргөн газар; хөнтөргөн ор.*

ХӨНТӨРГӨНДӨХ хэтэрхий хөнтөргөн болох.

ХӨНТӨРГӨХ хөнтрөхөд хүргүүлэх, хөнтрүүлэх.

ХӨНТРӨГДӨХ 1. хөнтрөхийн үйлдэгдэх хэв; 2. хөнтөргөндөх.

ХӨНТРӨХ 1. сав суулга мэтийн амсрыг доош хандуулан хөмрөх; *хувинтай айргаа хөнтрөөд асгачихав;* 2. хөмрөх, тонгорцоглох; онхолдуулах; *машинатай шороогоо хөнтөрч асга; наад савтай хогоо эрэг рүү хөнтөрч орхи; уруу газар хөнтрөөд ойчив;* 3. юм хумыг цөлмөн дуусгах; *нэг данх цай хөнтөрч орхиод явав;* 4. ш и л ж с э н биеэс зайцуулах, хөндийрүүлэх; *ногдол үүргээ хөнтрөх гэж бодож байна; чи бас хөнтрөх санаа бий биз.*

ХӨНТРҮҮЛЭХ 1. хөнтрөхийн үйлдүүлэх хэв; 2. хөнтрөгдөх.

ХӨНХГӨР хөнхөр нүдтэй; *миний хөнхгөр охин, аавдаа хүрээд ир!*

ХӨНХИЙЛГӨХ хөнхийхөд хүргүүлэх.

ХӨНХИЙХ хөнхөр болон хувирах, хөнхгөр болох.

ХӨНХӨР хөнхгөр, хөнхийсөн нь.

ХӨӨ I юманд тогтсон утаа, гортог; *тогооны хөө; яндангийн хөө;* **хөө хар** (хав хар өнгө зүсэм): **хөө болох** (а. гай уршиг, балаг болох; б. хөө суух, хөөгэй болох); **хөө шиг дотортой** (маш муу санаатай); **бөөн хөө** (тэр биеэрээ хөөтэй адил).

ХӨӨ II: **хөө дээл, хөө хуяг** х у у ч и р с а н толгойгоор өмсөх, энгэргүй, төмөрлөгөөр хийсэн хувцас, урьдын цагт цэргийн хүмүүс өмсч байжээ.

ХӨӨ III уршиг, балаг; *хөө халдаахгүйг хичээх; хөө тарих; хөө чирэх; миний хөө чамд халдахгүй, бүү зов; хөөтэй хэрэг болов.*

ХӨӨ IV аялга; *аа хөө; юү гэнэ хөө.*

ХӨӨВӨР 1. малын хөндийрсөн үс ноос; *үхэр адууны хөөвөр; малын үс хөөврийг хаягдалгүй ашиглах нь чухал;* 2. хөнгөрсөн хөвсгөр зөөлөн юм; *хужиртай хөөвөр газар; хөөвөр сэвсгэр идээ.*

ХӨӨВӨРЛӨХ хөөврийг авах; *адуу хөөвөрлөх; ямаа хөөвөрлөх.*

ХӨӨВӨРЛҮҮЛЭХ хөөвөрлөхийн үйлдүүлэх хэв.

ХӨӨВӨРЧИН хөөвөрлөх хүмүүс.

ХӨӨГ тэмээ үхрийг хөдөлгөх туух зэрэгт уриалан зандах; аялга; *хөөг хөж!*

ХӨӨГДӨХ хөөхийн үйлдэгдэх хэв; *ажлаас хөөгдэх; нохойд хөөгдөх.*

ХӨӨГЛӨХ малыг хөөг хөөг гэж зандах.

ХӨӨГЧ х у у ч и р с а н сумыг захирсан зангийн дараах сумын хэргийг шийтгэх хүний тушаалын нэр; *орлон хөөгч; сумын хөөгч.*

ХӨӨДӨГДӨХ хөөдөхийн үйлдэгдэх хэв.

ХӨӨДӨХ 1. юманд хөө түрхэх, халдаах; *би хонио нуруун дээр нь хөөдөж тэмдэглэсэн;* 2. бусдын үйл ажилд садаа зэтгэр учруулах, хор хүргэх, балаг уршиг болох; *тэр миний ажлыг нэгмөсөн хөөдөж гүйцэв.*

ХӨӨДҮҮЛЭХ 1. хөөдөхийн үйлдүүлэх хэв; 2. хөөдөгдөх.

ХӨӨЕ дуудахад хэрэглэх аялга; *хөөе, чи наашаа ир! хөөе, би энэ өдөр маш сонин юм үзэв; хөөе, хүлээж бай!*

ХӨӨЛГӨХ 1. хөөхийн үйлдүүлэх хэв; 2. хөөгдөх.

ХӨӨЛӨНТИЙ а м ь т а н цэнгэг усанд орших, улаавтар сэлүүртэй нэг зүйл загас.

ХӨӨЛӨХ юманд халдсан хөө тортгийг арилгах; *тогоо хөөлөх; яндан хөөлөх.*

ХӨӨЛҮҮЛЭХ хөөлөхийн үйлдүүлэх хэв.

ХӨӨЛҮҮР I яндангийн хөөг арилгахад хэрэглэх хэрэглэл.

ХӨӨЛҮҮР II бодон гахайн умдагны үгт наалдаж ургасан зүйл.

ХӨӨЛЦӨХ хөөхийн үйлдэлцэх хэв, харилцан хөөх.

ХӨӨМИЙ I нарийн үст амьтны өөхийн дагуу арьсны өнгө төсөөтэй хэсэг хувь газар; *булганы хөөмий; үнэгний хөөмий; тасын хөөмий; хөтөл дээр хөөмий мэргэн, хөлөө жийсэн жимий мэргэн* о н ь с г о.

ХӨӨМИЙ II тагнайн үг; **хөөмийн гүн** (тагнайн үгт хөнтрөн ургасан мах).

ХӨӨМИЙДӨХ хөөмийгөөр дуугарах, хөөмийлөх.

ХӨӨМИЙЛӨХ I нарийн үст амьтны хөөмийн хэсгийг авах; *булганы арьс хөөмийлөх.*

ХӨӨМИЙЛӨХ II хөөмийгөөр дуу аялах.

ХӨӨМИЙЛҮҮЛЭХ хөөмийлөхийн үйлдүүлэх хэв.

ХӨӨНГӨ I агаарт тогтсон хөх униар; *ногооны хөөнгө.*

ХӨӨНГӨ II баахан хавдаж цэлхэрсэн байдал; *нүүр нь хөөнгө суужээ.*

ХӨӨНГӨРӨХ хөөнгөтөх, униар хөөнгө татах.

ХӨӨНГӨТӨХ хөөнгө бий болох; *шилбэндээ нилээд хөөнгөтжээ.*

ХӨӨНӨ ургамлын мөлхөн ургах иш.

ХӨӨР юмны бах шим; **баяр хөөр, найр хөөр** х о р ш.; *хөөртэй бахтай найрлав; найр хөөр хийв; хөөр сонирхолгүй юм; чи битгий хөөр бах болоод бай; хөөр барих; хөөр болох.*

ХӨӨРГӨН онгиргон, сагсуу; *хөөргөн хүн хөл алдах.*

ХӨӨРГӨХ I 1. хөөрөхөд хүргүүлэх, хөөрүүлэх; 2. санааг тэжээж хөхүүлэн хөгжөөх; 3. онгируулах, ёргиулах.

ХӨӨРГӨХ II дээш дэгдээх, огшуулах, хэтэрхий шуух; *пуужин хөөргөх; цаасан шувуу хөөргөх; дээлээ дээш нь хөөргөж бүслэх.*

ХӨӨРГҮЙ баяр хөөргүй, цэнгэлгүй, урмасгүй.

ХӨӨРГҮҮ хөөргөн, онгиргон, сагсуу.

ХӨӨРӨГ I гал үлээлгэн хөгжөөх зэвсэг; *авдран хөөрөг; тулман хөөрөг; заримдаг тулман хөөрөг; гар хөөрөг;* **усан хөөрөг** (ус цацаж шүрших багаж зэвсэг).

ХӨӨРӨГ II гүүр; **зам хөөрөг** х о р ш..

ХӨӨРӨГ III хамарт үнэрлэж хэрэглэх тамхи хийх сав; *манан хөөрөг; шаазан хөөрөг; хөөрч байж хөөргөө хагалав даа.*

ХӨӨРӨГДӨХ 1. гал зэргийн юмыг хөөргөөр үлээлгэх; *гал хөөрөгдөж ноцоох;* 2. нүх сүвээр салхи үлээх; *гэрийн хаяагаар салхи хөөрөгдөх;* 3. буцдыг далдуур муутган ховлох; *далдуур хөөрөгдөж явдаг даан ч муухай зангай хүн.*

ХӨӨРӨГДҮҮЛЭХ 1. хөөрөгдөхийн үйлдүүлэх хэв; 2. хөөрөгдөгдөх.

ХӨӨРӨЛДӨӨН ярилдаан, зөвлөлдөөн; *хөөрөлдөөн хийх.*

ХӨӨРӨЛДӨХ хөөрөх III-ын үйлдэлдэх хэв.

ХӨӨРӨЛТ хөөрөх үйлийн нэр; *хөөрөлт сайтай; хөөрөлт муутай; хөөрөлт нь их; хөөрөлт нь бага.*

ХӨӨРӨЛХӨГ хөөрхөг, хөөргүү зантай; *хөөрөлхөг хүний үгийг итгэхэд бэрх.*

ХӨӨРӨЛХӨХ хүний мэдсэн чадсандаа эрэмшин омөрхох, хөөрөлхөг зан гаргах.

ХӨӨРӨЛЦӨХ хөөрөх III-ын үйлдэлцэх хэв.

ХӨӨРӨМТГИЙ их л хөөрдөг.

ХӨӨРӨМХИЙ хөөрөх зан байдалтай.

ХӨӨРӨӨ 1. яриа; **яриа хөөрөө** х о р ш.; *их л яриа хөөрөөтэй хүн байна билээ;* 2. хөөргүү зантай.

ХӨӨРӨХ I дэгдэх, дээшлэн эчих, дэврэх; *сүү буцлан төвийж хөөрөх; цаас салхинд үлээгдэж дэгдэн хөөрөх; үүл хөөрөх; хөөрч асгарах; малын үс ноос хөндийрч хөөрөх; үүл хөөрвөл бороо орох, үг хөөрвөл хэрүүл болох* з ү й р.

ХӨӨРӨХ II сэтгэл хөгжих, баярлах, бах болох; *миний морь хөөрч давхиад амыг нь татаж дийлэхгүй сандрав; манай хүү, сайн шалгагдсандаа бүр хөөрчихжээ; хөөрч байж хөлөө битгий хугалчихаарай.*

ХӨӨРӨХ III хүүрнэн ярих, хэлэлцэх; **ярих хөөрөх** х о р ш.; *ярих хөөрөхдөө чадамгай; хөөрөх дуртай хүн.*

ХӨӨРӨХ IV хүний биед жигд тэнцүү, тархмал байвал зохих зүйл замын ямар нэгэн шалтгаанаар тэнцүүртэй байдлаа алдаж дээш гүйж хэтрэх; *хий хөөрөх; цус хөөрөх; дотуур хөөрөх; гадуур хөөрөх.*

ХӨӨРТЭЙ баяртай, бахтай, урмастай, хөгжөөнтэй.

ХӨӨРҮҮ I дэврүү, хөөрөлхөг, онгироо, сагсуу.

ХӨӨРҮҮ II: **хөөрүү бааруу** гүйц хөөрөлт ихтэй.

ХӨӨРҮҮЛЭХ хөөрөхийн үйлдүүлэх хэв.

ХӨӨРХИЙ 1. бусдыг энэрэн өрөвдөх санаат илэрхийлэхэд хэрэглэх аялга; *хөөрхий, хилс*

зүдүүрийг хүлээж байна; хөөрхий, өрөвдмөөр болжээ; 2. дотно хайртайн учир тансаглах аялга; *хөөрхий, тийм хөөрхөн аальтай; хөөрхий, ийм томоогүй зантай;* 3. сэргэлэн чадамгайг бахдах аялга; *хөөрхий, эрдэм ухаан нь их; хөөрхий, ид хүч нь гарамгай.*

ХӨӨРХИЙЛӨЛТЭЙ хөөрхийлбэл зохих зүйл бий.

ХӨӨРХИЙЛӨХ энэрэх санаагаар өрөвдсөн байдлаа илэрхийлэх; *тийм амьтныг эрхбиш хөөрхийлөх хэрэгтэй.*

ХӨӨРХИЙЛҮҮЛЭХ 1. хөөрхийлөхийн үйлдүүлэх хэв; 2. хөөрхийлөгдөх.

ХӨӨРХӨГ биеэ баримтлах бардам зан аальтай, онгиргон, хөөрүү, сагсуу.

ХӨӨРХӨН сайхан, цэвэр, гоёмсог; *хөөрхөн аальтай хүүхэд; хөөрхөн хэлбэртэй морь; хөөрхөн хүүхэн; хөөрхөн хүүхэн хөөнд боодолтой* о н ь с г о.

ХӨӨС шингэн юмны дотоодод хий орж цөврүүтэн хөвсөн юм; *сүүний хөөс; усны хөөс; савангийн хөөс;* **хөөс тогтох** (хөөс бий болох); **хөөс сагах** (хөөсний улмаар дэврэн хөөрөх); **хөөс цахрах** (амьтны амнаас хөөс хөврөн гарах; *хөөс цахруулан ярих);* **хөөс замхрах** (хөөс нь намд намдсаар арилах): **далайн хөөс** (сувд мэт байдалтай хиймэл зүйл); ☆ **хөөсөн цавь** (цавины нугалааны орчин газар).

ХӨӨСДӨХ дэндүү хөөстэй болох.

ХӨӨСЛӨГ 1. хөөс нь их; 2. хөөсөрхүү.

ХӨӨСЛӨХ 1. хөөсийг нь авах; 2. хөөс тогтох.

ХӨӨСӨРХӨГ хөөс ихтэй, хөөсөрхүү.

ХӨӨСӨРХҮҮ 1. хөөсөрхөг; 2. хөөс мэт байдалтай.

ХӨСРӨГ их хөөсөрдөг юм.

ХӨӨСРӨХ хөөс тогтох, хөөс гарах; *сүү хөөсрөх.*

ХӨӨСРҮҮЛЭХ хөөсрөхийн үйлдүүлэх хэв.

ХӨӨСТӨХ хөөстэй болох, хөөс тогтох.

ХӨӨСТЭЙ хөөс бүхий юм; *хөөстэй ус;* **хөөстэй ундаа** (шингэлэн исгэж хөөсрүүлсэн хоормог).

ХӨӨТӨХ хөө тогтох, хөөтэй болох; *гэр хөө-төхөөс болгоомжил!*

ХӨӨТЭЙ хөө бүхий юм; *хөөтэй тогоо;* **хөөтэй төлөг шиг** (үзэмж байдал муухай юм); **хөөтэй гайтай** (уршиг нөлөө ихтэй); **хөөтэй хэрэг** (уршиг нөлөө ихтэй үйл явдал).

ХӨӨХ I үлдэх, илгээх; *зайлуулан хөөх; нэхэмжлэн хөөх; хөөж гүйцэх; хойноос нь хөөх; намаас хөөх.*

ХӨӨХ II юмны хөөнгөрөх, томрох, сэвсийх, зузаарах; *усанд дэвтэж хөөх; халж ялзран хөөх; хий дүүрч хөөх; хавагнаж хөөх; сэвсийж хөөх.*

ХӨР I хатуурч тогтсон юм; *цасны хөрсөх; бууцны хөр.*

ХӨР II хөөр; *найр хөөр; хөр болох.*

ХӨРВӨӨЛГӨХ хөрвөөхийн үйлдүүлэх хэв.

ХӨРВӨӨХ 1. хөрвөх; 2. хөрвөхийн үйлдүүлэх хэв.

ХӨРВӨХ I хүний санаа зан урваж эргэх, хөлбөрөх; **урвах хөрвөх** х о р ш..

ХӨРВӨХ II амьтны хэвтэж бие хөлбөрөн налах; **налах хөрвөх** х о р ш.; *морь хөрвөх; хүүхэд хөрвөж наадах.*

ХӨРВӨШ 1. бие загатнан гүвдрүүтэх нэгэн зүйл өвчин; *чоныи хөрвөш;* 2. морины тагнай хавдах нэгэн зүйл өвчин.

ХӨРВӨШЛӨХ хөрвөш өвчин хүрэх ба дэгдэх.

ХӨРВҮҮЛЭХ 1. хөрвөхийн үйлдүүлэх хэв, урвуулах, эргүүлэх, хөлбөрүүлэх; 2. орчуулах; *оросоос монголд хөрвүүлэх.*

ХӨРГӨХ хөрөхөд хүрүүлэх.

ХӨРГҮЙ хөөргүй.

ХӨРГҮҮР хөргөж хүйтэн болгодог хэрэглэл; *хөргүүр сав.*

ХӨРДӨХ зүлгэх, засах, зүлгүүрдэх; *чулуу хөрдөх; төмөр хөрдөх;* **хөрдөх элс** (чулуу засахад хэрэглэх элсэн зүлгүүр).

ХӨРЗГӨР юмны байдал бүдүүлэг ширүүн, бүрзгэр мэт; *хөрзгөр царайтай; хөрзгөр хөрс-тэй.*

ХӨРЗИЙЛГӨХ хөрзийхөд хүргүүлэх, хөрзгөр болгох.

ХӨРЗИЙХ юмны өнгө, арьс хөрс нь ширүүн арзгар болох, зузаарч барвайх, хөрзгөр болох.

ХӨРЗӨН хонь ямааны баас шээс хөлдөж дагтаршсанаас тогтсон хөр; **хөр хөрзөн, бууц хөрзөн** х о р ш..

ХӨРЗӨНТӨХ хөрзөн тогтох.

ХӨРЗӨНТҮҮЛЭХ хөрзөнтөхийн үйлдүүлэх хэв.

ХӨРЛӨХ хөр болох, хөртөх; *цас хөрлөх; бууц хөрлөх.*

ХӨРМӨГ модны навч намар цаг зулгарч газарт дэвсэн унасны нь; *цэцэрлэгийн улиасны хөрмөг маш зузаан болжээ.*

ХӨРӨГ юмны дүр байдлыг дууриалган хийсэн зураг дүрс, цутгамал, сийлмэл, баримал, зурмал, буулгамал; *чулуун хөрөг; баримал хөрөг; зормол хөрөг.*

ХӨРӨГЛӨХ хөрөг болгож хийх.

ХӨРӨНГӨ I хүний хийгээд улс нийгэмд хамаарагдах өмч, үнэ бүхий зүйлийн нийт нэр; *улсын хөрөнгө; олон нийтийн хөрөнгө; хувийн хөрөнгө; өмчийн хөрөнгө; амины хөрөнгө;* **хөрөнгө зөөр** (а. бүхий л юм; б. алт мөнгө зэрэг үнэ бүхий зүйл); **хөрөнгө чинээ** (хүний хуримтлуулсан хөрөнгө юм; *хөрөнгө чинээ сайтай; хөрөнгө чинээгүй);* **эд хөрөнгө** (эд юм); **хөрөнгө хогшил** (бүхий л хөрөнгө юм): **хатуу хөрөнгө** (алт мөнгө зэрэг үнэ бүхий хөрөнгө); **бэл хөрөнгө, эх хөрөнгө** (суурь, үндэс болсон хөрөнгө); **хөрөнгө тусгаарлах** (гэр өрх тусгаар болж, хөрөнгө юмаа хуваах); **хөрөнгө цайрах** (маш ядуурч хоосрох); **хөрөнгийг цайлгах, хөрөнгийг цайруулах** (бүх хөрөнгийг цөлбөн үрэгдүүлэх, хураах); **хөрөнгө хураах** (а. эд юмыг хурааж хуримтлуулах; б. ял хэргийн учир буюу өр ширд өмч юмыг албадан авах): **бэлтгэл хөрөнгө, нөөц хөрөнгө** (хөмрөгт хадгалж байгаа эд юм, мөнгө; *бэлтгэл хөрөнгөнөөс гаргах);* **гүйлгээний хөрөнгө** (түүхий эд, түлш зэрэг эргэлтийн хөрөнгө); **үндсэн хөрөнгө** (барилга, байшин, машина зэрэг хөрөнгө); **хувь нийлүүлсэн хөрөнгө** (хувь хуралдуулан бий болгосон хөрөнгө); **хөдлөх хөрөнгө** (байшин, хашаа, газар зэргээс бусад эд хөрөнгө); **үл хөдлөх хөрөнгө** (байшин, хашаа, газар зэрэг байран хөрөнгө); **хөрөнгө оруулалт** (аливаа барилга төхөөрөмжид зарцуулах хөрөнгө).

ХӨРӨНГӨ II 1. идээний зүйлийг исгэх, хольцоо, хатуу хөрөнгө ч гэдэг; *тараг айрагны хөрөнгө; барсны хөрөнгө; талхны хөрөнгө;* 2 тарианы зүйлийг тарьж ургуулахад тавих үрийн зүйл; **үр хөрөнгө** х о р ш.; **хөрөнгө цацах** (үр цацах): ☆ **өвчний хөрөнгө** (а. эрүүл ухаантай биш юм шиг зан аальтай; б. ямагт өвчин зовлонгоос салдаггүй); **будлианы хөрөнгө** (а. юманд хүрэлцвэл л будлиантуулж байдаг этгээд; б. будлиан болгосон үндсэн шалтгаан).

ХӨРӨНГӨДӨХ хөрөнгө нь ихдэх.

ХӨРӨНГӨЖИХ хөрөнгөтэй болох, хөрөнгө нь арвижих.

ХӨРӨНГӨЖҮҮЛЭХ хөрөнгөжихийн үйлдүүлэх хэв, хөрөнгөтэй болгох.

ХӨРӨНГӨЛӨГ хөрөнгөт, хөрөнгөтэй.

ХӨРӨНГӨЛӨХ айраг тараг буюу дарс зэргийг исгэхээр хөрөнгө **тавьж** хийх; *тэднийх хөрөнгөлж гэнэ билээ.*

ХӨРӨНГӨТ 1. хөрөнгө бүхий, чинээлэг; 2. хөрөнгөтний засгийн ёс дэглэм бүхий; *хөрөнгөт ёс.*

ХӨРӨНГӨТӨН буржуйн нийгэм дахь ноёрхогч ангийн төлөөлөгч бөгөөд хөдөлмөрчдийг дарлан мөлжих замаар олсон их хөрөнгийг хувьдаа эзэмшигчид, ардчилал ба хөдөлмөрчдийн эсрэг тэмцэгч, капиталист, дайсан.

ХӨРӨӨ (Н) I огтлох зүсэх багаж; *төмрийн хөрөө; модны хөрөө; цахилгаан хөрөө; цүзгэр хөрөө; гар хөрөө;* **хөрөөний ир** (хөрөөний шүд); **хөрөөний гар** (хөрөөний тэлүүр мод); **хөрөөний эрээс** (хөрөөний гарыг холбож тэлэх оосор); **хөрөөний эрээдэс** (хөрөөний эрээсийг мушгиж чангаруулах бяцхан мод); **хөрөөний ир шиг** (хөрөөний ир мэт: *хөрөөний ир шиг бичигтэй).*

ХӨРӨӨ II урсгал усны хоёр захаас эхлэн хөлдсөний нь; *гол хөрөөлж хөлдөв; усны хөрөө цөмрөхгүй болжээ.*

ХӨРӨӨДӨХ I юмыг хөрөөгөөр огтлох, зүсэх; *мод хөрөөдөх; төмөр хөрөөдөх.*

ХӨРӨӨДӨХ II хүн амьтны зам буюу гол мөрөн зэргийг хөндлөнгөөр нааш цаашгүлжиж зорчин явах; *ус хөрөөдөх; зам хөрөөдөх.*

ХӨРӨӨДҮҮЛЭХ хөрөөдөхийн үйлдүүлэх хэв.

ХӨРӨӨЛӨХ урсгал усны хоёр захаас эхлэн хөлдөх; *голын ус хөрөөлөн хөлдөж эхлэв.*

ХӨРӨӨХ 1. хөрөхийн үйлдүүлэх хэв, хөргөх; 2. сүү зэргийг хөлдөөх; *сүү хөрөөх.*

ХӨРӨХ 1. халуун юмны жихүүн хүйтэн болох; *цай хөрөх;* 2. даарах; **даарах хөрөх** х о р ш.; *хүйтэнд хөрч, халуунд халж явав.*

ХӨРС I 1. юмны гадаад өнгөн этгээд; *газрын хөрсний байдал хөрсөн дорхи ус; хөрс судлах;* **хөрс судлал** (газрын хөрсийг судлах ухаан); **хөрс судлалч** (хөрс судлалд мэрэгжисэн хүн); 2. үст юмны үсний нөгөө этгээд тал; **арьс хөрс** х о р ш.; *хөрс зузаан; хөрс нимгэн; үс хөрс нийлсэн сайхан арьс.*

ХӨРС II юмны чанар байдлыг заахад хэрэглэнэ; *царайлаг хөрстэй хүүхэд; хөрстэй сайхан мал; хөрс сайтай; хөрс муутай.*

ХӨРСЖИХ хөрстэй болох, хөрс суух.

ХӨРСЖҮҮЛЭХ хөрсжихийн үйлдүүлэх хэв.

ХӨРСЛӨГ хөрс сайтай; *хөрслөг залуу.*

ХӨРСЛӨХ 1. арьс хөрсийг шалбаруулах ба юмыг нимгэнээр халчин авах; *хуйхы нь хөрслөв;* 2. юмны хөрсий нь авах.

ХӨРТЭЙ хөөртэй, хөөр бах ихтэй.

ХӨРХ биеийг буюу юм хумыг халхлан татах хөшиг; *орны хөрх.*

ХӨРХЛӨХ хөрх татах.

ХӨРХРӨӨ өндөр өнгийм газраас доош бууж урсах ус, хүрхрээ ч гэдэг.

ХӨРШ айл зэргэлдээ, залгаа; **айл хөрш** х о р ш.; *хөрш айл; хөрш улс.*

ХӨСӨГ уналга ачлага; *морин хөсөг; тэмээн хөсөг; үхэр тэргэн хөсөг; хөсөг хөдөлгөх;* **ердийн хөсөг** (тэмээ, үхэр, адуугаар юм тээх тээвэр); **авто хөсөг** (авто машинаар хийх тээвэр).

ХӨСӨР газар, хээр; **хөсөр хээр, газар хөсөр** х о р ш.; *хөсөр орхих; хөсөр суух;* **хөсөр даах** (өгөр зэвхий болох); **хөсөр юм** (хээр хэвтсэн юм); **хөсрийн яс** (хээр хэвтэж хувхайрсан яс).

ХӨСӨРДӨӨХ хөсөрдөхөд хүргүүлэх, хөсөрдүүлэх.

ХӨСӨРДӨХ 1. газардах; 2. эзэнгүй болох, анхаарлаас гадна хоцрох.

ХӨСӨРДҮҮЛЭХ хөсөрдөхийн үйлдүүлэх хэв; *тэр чухал ажлыг хөсөрдүүлэн орхижээ.*

ХӨСӨРШИХ хөсөр болох, хөсөр шинжтэй болох.

ХӨСРИЙ хөсөр, хээр хэвтсэн юм.

ХӨСРИЙТӨХ хөсрий байдалтай болох.

ХӨСРИЙШИХ хөсрий шинжтэй болох.

ХӨТЛӨГДӨХ хөтлөхийн үйлдүүлэх хэв.

ХӨТЛӨГЧ хөтөлдөг хүн; *хэрэг хөтлөгч; хөсөг хөтлөгч;* **морь хөтлөгч** (цэргийн дээд тушаалын дарга нарт үйлчлэгч хүн).

ХӨТЛӨЛДӨХ хөтлөхийн үйлдэлдэх хэв, хөтөлцөх.

ХӨТЛӨЛЦӨХ хөтлөхийн үйлдэлцэх хэв, хөтөлцөх.

ХӨТЛӨХ 1. юмнаас барьж дагуулан явах; *морь хөтөлсөн хүн ирлээ; тэмээ хөтлөх; хүүхэд хөтөлсөн хүн айсуй; нохой хөтөлсөн анчин;* 2. ш и л ж с э н удирдан залж дагуулах, хөдөлгөх, хөтөлбөрлөх; 3. ш и л ж с э н юмыг тогтоосон маяг журмаар хийх, үйлдэх; *данс хөтлөх; хэрэг хөтлөх;* 4. ш и л ж с э н нэг юмыг ийш тийш нь чирч заах; *бичгийн оруулгыг чирч хөтлөх.*

ХӨТЛҮҮЛЭХ 1. хөтлөхийн үйлдүүлэх хэв; 2. хөтлөгдөх.

ХӨТӨВЧ шээх сав.

ХӨТӨЛ I хөтөч.

ХӨТӨЛ II уул нурууны дөлгөөн буусан нам нахис газар; *баруун уулын хөтлөвөр баахан хүмүүс гарч айсуй!*

ХӨТӨЛБӨР 1. дагаж мөрдлөг болговол зохих юм; *ажлын хөтөлбөр; мөрийн хөтөлбөр;* 2. хичээллэх зүйлийн төвч агуулга, программ; *хичээлийн хөтөлбөр;* 3. театр цонцерт зэрэгт үзүүлэх зүйлийн жагсаалт; *цонцертийн хөтөлбөр.*

ХӨТӨЛБӨРЛӨХ бусдыг үйл явдалд дагуулан давшуулан удирдах.

ХӨТӨЛГӨӨ сул хөтөлж явах морь мал; *хөтөлгөө морь.*

ХӨТӨЛЦӨӨЛГӨХ хөтөлцөөхийн үйлдүүлэх хэв.

ХӨТӨЛЦӨӨХ хөтөлцөх, хөтлөлцөх.

ХӨТӨЛЦӨХ хөтлөхийн үйлдэлцэх хэв, хөтлөлцөх.

ХӨТӨЛЦҮҮЛЭХ хөтөлцөхийн үйлдүүлэх хэв.

ХӨТӨЧ бусдыг дагалдан явах зарц хүн, **хөтөл** ч гэдэг; *аялан явагчдын хөтчөөр явах.*

ХӨХ I номин чулууны адил өнгө, үндсэн өнгүүдийн нэг; *хөх бух модон дөртэй* о н ь с г о; **хөх цэнхэр, цэнхэр хөх** (цагаавтар хөх өнгө); **хөх саарал** (үнсэн өнгө); **хөх бор** (боровтор хөх өнгө); **хар хөх** (гүн хөх, бараавтар хөх); **хөх болох** (юмны өнгө зүс хөхрөх; *хөх царай; хөх аргал; хөх хомоол);* **хөх тэнгэр, хөх огторгуй, хөх агаар** (хөхрөн харагдах хөндий агаар); **хөх сарьс** (ногоон өнгийн сарьс); **хөх хас** (хас чулууны нэг зүйл, өнгө номины адил); **хөхийн шашин** (буддын шашны хятадад дэлгэрсэн нэг зүйл шашин суртахуун); **хөх ногоо** (хөврөн ургаж байгаа ногоо; *хөх ногооны шим);* **хөх униар** (ногооны уурын униар); **хөх утаа** (утааны хөхрөн харагдах өнгө); **хөх өвс** (хадаж аваад ногоон хэвээрээ хатсан өвс, ногоон өвс ч гэнэ); **хөх хаг** (чийгтэй газрын мод чулуунд гарах ногоовтор өнгөтэй нэгэн зүйл ургамал); **хөх сэрх** (ямаахай гэдэг ургамлын жил өнжисний нь); **хөх арвай** у р г а м а л (нэг зүйл арвай); **хөх будаа** у р г а м а л (нэг зүйл тариа); **хөх яргуй** у р г а м а л (яргуйн нэг зүйл, цэцгийн өнгө хөх, гурван хэлтэстэй); **хөх хархираа** а м ь т а н (тогоруутай адил байдалтай, үнсэн өнгөтэй, хушуу урт, метр орчим өндөр биетэй нэгэн зүйл шувуу, гэрт тэжээж болно, өнгөтэй хувцас өмссөн хүн үзэгдвэл дуугарч бүжиглэн, дагаж цохилон наадна); **хөх болжмор** а м ь т а н (хитрүү бялзуухайтай адил бөгөөд хөх толгойтой, сүүлний хоёр хажуу цагаан, нүүдлийн шувуу); **хөх ногтруу** а м ь т а н хахилагийн нам, хөвчин бие алаг, хар бидэрт шар сэвхтэй, хөлдөө шар ноолууртай нэг зүйл шувуу); **хөх тэглэй** а м ь т а н (цагаан тэглэйгээс баахан их, толгой дээрээ гурван өрөвлөгөтэй, бараан шар хольцолдсон өнгөтэй нэгэн зүйл шувуу); **хөх цэгцгий** а м ь т а н (зун ирдэг нэгэн зүйл бялзуухай, өнгө хөх, хүзүү бараан, өвчүү цагаан, гол хөдөө алинд ч байдаг); **хөх бух** а м ь т а н (бух шиг урамддаг нэгэн зүйл шувуу, усны бух ч гэдэг); **хөх бор азрага** а м ь т а н (өвчүү хөхөвтөрхөн, нуруундаа бараан бидэртэй, сүрэглэн нисдэг нэг зүйл бялзуухай); **хөх хатан хараа** а м ь т а н (хатан хараатай адилхан бөгөөд өрөвлөг өд хөх нэг зүйл шувуу); **хөх түрүү** а м ь т а н (ялаатай адил боловч бие том, амьтныг хатгах зуух нь хэцүү нэг зүйл ялаа); **хөх ялаа** а м ь т а н (ерийн ялаанаас том, өнгө ногоон, юм хуманд саг орхивол өт төрдөг нэг зүйл ялаа); ☆ **хөх инээд** (бусдад зэвүүрхэн хүйтнээр инээхийг).

ХӨХ II 1. амьтны үр зулзагаа тэжээх сүүний булчирхай: **хөх дэлэн** х о р ш.; 2. нялхаст шимүүлэх арьс зэргээр хийсэн юм; **хөх өрөх, хөх эрхэх** (хөхний сүү боогдож авсаар гарахгүй хавдан өвчлөх); **хөх ивлэх** (хүний сүү саамшран бууж нэмэгдэх); **хөхний товч** (хөхний толгой); **тэмээн хөх** у р г а м а л (зэрлэг гаймуутай адил чавга мэт ногоон цоморлог ургадаг зэрлэг ногоо, идэж болно).

ХӨХ III зэрлэг гахайн зулзага.

ХӨХ IV үхрийн омруу.

ХӨХДЭЙ а м ь т а н өнгө нь хөхөвтөр галбинга шувуу.

ХӨХЛӨГ бусдын санааг **хөгжөөх** нь; *хөхлөг болгох ажил явуулах.*

ХӨХӨВТӨР баахан хөх, нилээд хөх; *хөхөвтөр ногоон;* **хөхөвтөр богширго** а м ь т а н (гуа бялзуухайд адил, хушуу цайвар цагаан, нүд хар, биеийн хөвчин гүн хөхөвтөрхөн, хөл цагаан нэгэн зүйл бялзуухай).

ХӨХӨВЧ хөхний даруулга.

ХӨХӨГЧИН 1. эм амьтны хөх зүс; 2. сарны зурхайн ёсны арван иш гэдгийн хоёрдугаарт байх, бас бэлгийн мод ч гэнэ; *хөхөгчин туулай жил.*

ХӨХӨЛ I 1. хүүхэд багачуудын нялхын үсийг авахдаа үлдээсэн хэсэг үс; *хөхөл тавих хөхөл үлдээх;* 2. адууг дэллэхдээ толгой дээр нь үлдээсэн урт туг үс; *хөхөл дэл; хөхөлт борыгоо унаж хөдөө талаар давхиж явлаа би.*

ХӨХӨЛ II хүн амьтны бусдын үйл явдлыг дагаж сэтгэл хөгжихий нь; **хөхөл хөгжил** х о р ш..

ХӨХӨЛДӨХ хөгжилдөх, олноороо хөхөх.

ХӨХӨЛТ I 1. хөхөх үйлийн нэр, соролт, таталт; *хөхөлт сайтай бумба;* 2. төрсөн үрчилсэн биш боловч хөхөө хөхүүлсэн буюу хүмүүжүүлсэн хүн; **хөхөлт эх** (төрсөн үрчилсэн биш боловч хөхөө хөхүүлж өсгөсөн хүн); **хөхөлт эцэг** (хөхөлт эхийн нөхөр).

ХӨХӨЛТ II хөхөл бүхий; *хөхөлтэй хүүхэд; хөхөлт хээр морь.*

ХӨХӨЛТ III хөгжилт, бахдалт

ХӨХӨМДӨГ баахан хөхөвтөр өнгө; *хөхөмдөг бор морь; хөхөмдөг огторгуй;* **хөхөмдөг хүчил** (устөрөгч, хүчилтөрөгч, азотын нэгдлээс бүрдсэн хорт шингэн, үнэр муухай).

ХӨХӨӨ I а м ь т а н хяргуйтай адилхан, өнгө цагаавтархан нэг зүйл шувуу: **хөхөө донгодох** (хөхөө шувууны гүг гүү гэж дуугарах; *хөвчийн мод ногоорч, хөхөө шувуу донгодсон,*

хөгжилтэй сайхан зуны цаг ирэв); **эрт дуугарсан хөхөөний ам хөлдөх** (урьтаж дуугарсан нь хохирох); **хөхөө сар** (тавдугаар сар, хөхөөн дууны сар ч гэнэ); **хөхөөн дарс** у р г а м а л (хадархаг, хайрга хөрсөнд ургадаг, самрын боргоцойтой адил бөгөөд нарийхан нэгэн зүйл ногоо, исгэлэн ус хийж ууж болдог); **хөхөөн айраг** (туулайн тагнай гэдэг ургамлын өөр нэр).

ХӨХӨӨ II: **хөхөө өвөл** өвлийн тасгим хүйтэн; *хөхөө өвлийн хүйтэн; хөр цасны хайруу.*

ХӨХӨӨХ санаа зориг*ийг* тэжээн хөгжөөх.

ХӨХӨХ I хүн амьтны ур зулзага, эхийнхээ хөхийг шимэн сорох; *хүүхэд хөхөх; хурга хөхөх;* 2. хөхүүлгийн татаж сорох; *гоюу хөхөх; гурил хөхөх; бумба хөхөх; сүүл хөхөх.*

ХӨХӨХ II хүн амьтны бусдын үйл явдлыг дагаж сэтгэл хөгжих; **хөхөх хөгжих, хөөрөх хөхөх** х ө р ш.; *сэтгэл нь хөхөж улам сайн ажиллах болов.*

ХӨХӨЦ I а м ь т а н өнгө ногоон, хушуу урт, сүүл охор нэгэн зүйл бялзуухай; **хөхөц цэцэг** у р г а м а л (янз хөх болжморын адил, бие жигүүр сүүл цөм бий, шар тоорцог, хоёр нүдний мэт ургасан, үнэр ихтэй нэгэн зүйл ургамал).

ХӨХӨЦ II нэгэн зүйл хөх будаг, хөгц ч гэдэг; *чулуун хөхөц.*

ХӨХРӨЛДӨӨН олноороо инээлдэн хөгжихий нь.

ХӨХРӨХ I юмны өнгө хөх болж хувирах; *бие махбод хөхрөх; ногоо ургаж газрын өнгө хөхрөв; цай хөхрөх; царай хөхрөх;* **нүд хөхрөх** (нүдний хараа эцэх); **газар дэлхий хөхрөх** (газар ногоорох).

ХӨХРӨХ II инээх, их л тэсч ядан хагдганан инээх: **хөхөрч хөших, инээх хөхрөх** х о р ш.

ХӨХРӨХ III цөхрөх; *хүүхэд хөхөртлөө уйлав; чамайг ирнэ гэж хөхөртлөө харуулдав; гаа гайхаж, цэл хөхрөх.*

ХӨХРҮҮЛЭХ хөхрөх I II-ын үйлдүүлэх хэв, хөх болгох, инээлгэх. • .

ХӨХТӨН хөх бүхий амьтан; *хэхтөн амьтад.*

ХӨХҮҮЛ I ур зулзагаа хөхүүлдэг амьтад; *хөхүүл хүүхэдтэй; хөхүүл үнээ.*

ХӨХҮҮЛ II урамшуулал, сайшаал; *тушаалаар сайшаан хөхүүлэв.*

ХӨХҮҮЛЭГ I өвчний хорыг татуулахаар тавих элдэв эм юм.

ХӨХҮҮЛЭГ II хөгжөөлөг, урамшуулга.

ХӨХҮҮЛЭХ I хөхөх I-ийн үйлдүүлэх хэв; *хөхөө хөхүүлэх; давирхайгаар хөхүүлэх.*

ХӨХҮҮЛЭХ II хөхөх II-ын үйлдүүлэх хэв, урамшуулан хөгжөөх; *сайшаан хөхүүлэх.*

ХӨХҮҮЛЭХ III хүний бүгшин ханиалгах; *хөхүүлэн ханиах; хөхүүлдэг ханиад.*

ХӨХҮҮР I айраг тараг зэрэг шингэн зүйл агуулахын тулд шир хөм зэргээр хийсэн сав; *айргийн хөхүүр; хөхүүртэй айраг.*

ХӨХҮҮР II хамрын тамхи агуулах чулуулаг буюу шил шаазан мэтээр хийсэн бяцхан сав, хөөрөг ч гэдэг.

ХӨШИГ юмыг далдлах буюу салхи жавар зэргийг хаахаар хийсэн халхавч; *гэрийн хөшиг; орны хөшиг; цонхны хөшиг;* **утаан хөшиг** (утаагаар далдалсан халх); **хөшиг татах** (хөшиг зүүж халхлах).

ХӨШИГЛӨХ I 1. юмны наагуур халхавч хөшигтэй болгох; 2. хөшиг татсан мэт үзэгдэх; *хөшиглөн хаах; утаа хөшиглөх.*

ХӨШИГЛӨХ II юмыг хутга заазуур мэтээр хэсэг хэсэг болгож жижиглэн хэрчих, огтлох; *мах хөшиглөх; ногоо хөшиглөх.*

ХӨШИГЛҮҮЛЭХ хөшиглөхийн үйлдүүлэх хэв.

ХӨШИХ I юмыг гөнжих; **хөших гөнжих** х о р ш.; *модоор хөшиж өргөвөл хялбар; хадаасны үзүүрээр хөшиж гарга.*

ХӨШИХ II уян зөөлөн юмны хатуу чийрэг болон хувирах; *бие махбод өвдөж хөших; уе гишүү хатууран хөших; хэл хөших.*

ХӨШИХ III нэгэн зүйл оёдол, утсыг наад цаад талд нэвт хатгаж, ээлжлэн дамнуулж туус оёх; *дээлийнхээ өнгө дотор хоёрыг хөшөөд эргүүлбэл амар юм биш үү?*

ХӨШИХ IV үйл хэрэгт хөндөлдөн хөшөөлөх, тээг болох; *энэ ажилд хөндлөнгөөс оролцож хөших ямар хэрэг байна? чамд.*

ХӨШӨӨ I ямар нэгэн тэмдэг, дурсгал болгож босгосон зүйл; *хөшөө чулуу; хөшөө дурсгал; хөшөө пайлуур; хөшөө босгох; Сүхбаатарын хөшөө.*

ХӨШӨӨ II хөшүүн, зөрүүд.

ХӨШӨӨЛӨХ үйл хэрэгт хөндөлдөн татгалзаж зүтгэлхийлэх зэргээр хөших.

ХӨШҮҮДЭХ хэтэрхий хөшүүн болох.

ХӨШҮҮЛЭХ хөшихийн үйлдүүлэх хэв.

ХӨШҮҮН I уян зөөлөн биш хатуу; *хатуу хөшүүн эд; хөшүүн амтай морь; хөшүүн хатуу нум.*

ХӨШҮҮН II зан ааль эелдэг биш, зөрүүд; *хөшүүн хүнийг аяы нь олж сургаж хүмүүжүүлэх хэрэгтэй.*

ХӨШҮҮР 1. юмыг хөндөлдүүлж тээглэн бэхлэх хэрэглэл; *хаалганы хөшүүр; үүдний хөшүүр;* 2. хөшүүрэг; *хөшүүр сургааг;* 3. гөнжүүр; *хөшүүр төмөр.*

ХӨШҮҮРДЭХ юмыг хөшүүрээр өргөж хөших, гөнжих.

ХӨШҮҮРЛЭХ хөшүүрээр хөшиж тогтоох, бэхлэх.

ХӨШҮҮРҮҮЛЭХ хөшүүрэхийн үйлдүүлэх хэв, хөшүүн болгох.

ХӨШҮҮРХЭХ хөшүүн зан байдал гаргах.

ХӨШҮҮРЭГ 1. юм хумыг өргөх татах зэрэгт хэрэглэх хөшүүр; *хөшүүргийн хүч их;* 2. баавгай агнахад нүхний амсарт хөшиж шаахаар тохируулсан сургааг мод; **хөшүүрэг шаах** (баавгайг агнахад ичсэн нүхний нь амсарт хоёр хэсэг сургааг модыг хөшин хатгаж довтлон гарахыг саатуулан түдээх).

ХӨШҮҮРЭГДҮҮЛЭХ хөшүүрэгдэхийн үйлдүүлэх хэв.

ХӨШҮҮРЭГДЭХ хөшүүргээр хөшиж өргөх, тулах.

ХӨШҮҮРЭХ хөшүүн болох. хатуурах.

ХӨШҮҮТЭХ улмаар хөшүүн болох.

ХРОМ I химийн махбод, хатуу болоод өнгөлөг төмөрлөг.

ХРОМ II торгон савхи; *хромон гутал.*

ХРОНОМЕТР огт зөрүүгүй явдаг нэг зүйл цаг.

ХУ 1. хүнд хөнгөний хэмжээ, пунг зуу хуваасны нэг хувь; *зуун ху нэг пун;* 2. урт богиның хэмжээ, ямхыг арав хуваасны нэг хувь; *арван ху нэг ямх;* **ху хаа** (хүйтэнд тэсэхгүй дагжиж чичрэхэд гарах аялга; *ху хаа, яасан сүрхий даарч байх юм бэ!*).

ХУА I 1. цайвар улаан буюу бүдэх шаравтар өнгө; *хуа улаан; хуа хонд;* 2. **малын зүс,** цайвар улаавтар өнгө; *хуа зээрд морь; хуа улаан үхэр.*

ХУА II аюу тавиу гүдгэр зоо нуруу газар; *цантын хуад олон мал билчээрлэж явав.*

ХУА III дуу аялуулан арван хуруугаар тоо таалцах нэгэн зүйл тоглоом.

ХУАЖУУ у р г а м а л халуун оронд ургадаг нэгэн зүйл ургамлын үр, халуун чанартай, эмнэлэгт хэрэглэнэ, мөн хоолонд ч хэрэглэнэ ярам ч гэдэг.

ХУАЙЗ хуайс будаг.

ХУАЙС у р г а м а л буурцагт ургамлын язгуурын бүтлан ургадаг нэг зүйл мод, хуайз ч гэдэг, үрээр нь юм будна.

ХУАЛАХ дуу дуулж, хуруугаар тоо таалцаж наадах.

ХУАЛУУЛАХ хуалахын үйлдүүлэх хэв.

ХУАНГУА у р г а м а л түүхийгээр идэж болдог нэгэн зүйл ногоо, хэмх ч гэдэг.

ХУАНГУЙ ПЕЙ х у у ч и р с а н хааны хоёрдугаар хатан.

ХУАНДИЙ х у у ч и р с а н улсын эзэн хаан.

ХУАНЛИ цаг улирлын тооны бичиг.

ХУАНЛИН у р г а м а л цөс өвсний үндэс, эмнэлэгт хэрэглэнэ, шар будаг гаргана.

ХУАНТАЙЗ х у у ч и р с а н хааны тэргүүлсэн хөвгүүн буюу суурь залгамжлах хөвгүүн.

ХУАНХҮҮ х у у ч и р с а н хааны эх буюу их хатан.

ХУАР 1. цэцэг; **цэцэг хуар** х о р ш.; 2. элдэв зураг, хээ угалзын зүйл; **хээ хуар, зураг хуар** х о р ш.; 3. бодоо өвчний цээрлэсэн нэр.

ХУАРАГНАХ цэргийн хуарандаа байрлан сууж орших.

ХУАРАГНУУЛАХ хуарагнахын үйлдүүлэх хэв.

ХУАРАН цэргийн орших байр газар; *Улаан хуаран.*

ХУАРЛАХ юманд хээ угалз тавьж чимэглэх.

ХУАРТАХ цэцэг өвчнөөр өвдөх.

ХУАСАН нэгэн зүйл том самар; *хуасангийн идээ; хуасан цөмөх.*

ХУВ (АН) I давирхай мэт нэгэн зүйл хатуу эд; чимэгт хэрэглэнэ; *шар улаан хув; хуван соруул;* **хув дээл** (аливаа үст хүрэм, дээлд өнгө татаагүйг нь, өнгө дээл, хүрэм).

ХУВ II хүн амьтны чихгүйг буюу асар бага чихтэйгий нь; **хув хулгар** х о р ш.; *хув хонь; хув толгойт.*

ХУВ III хүч нэмэгдүүлэх үг; **хув хуурай** (огт чийггүй).

ХУВААГДАГЧ 1. хуваах үйлд автагдагч; 2. хуваагчид хуваагдах тоо.

ХУВААГДАХ 1. хуваахын үйлдэгдэх хэв; 2. хувааж болох; *хоёрт хуваагдах тоо;* **сэтгэл хуваагдах** (а. аливаа зүйлд сэтгэл хоёрдох, гүйвах; б. нэг зүйлийг бодож атлаа бусад өөр юманд бодол санаа хувиарлагдах).

ХУВААГДМАЛ хуваагдах үйлийн нэр; *хуваагдмал байдал.*

ХУВААГЧ 1. хуваах этгээд; 2. хуваагдагчийг хуваах тоо.

ХУВААЛГАХ хуваахад хүргүүлэх.

ХУВААЛЦАХ хуваахын үйлдэлцэх хэв.

ХУВААХ хэсэглэх, хувь зохион салгаж ногдуулах; *ашиг хуваах; тоо хуваах; өмч хуваах; ажлаа хуваах; хэд хэдэн бүлэг болгож хуваах.*

ХУВАЙЛГАХ хувайхын үйлдүүлэх хэв.

ХУВАЙХ хувгар болох.

ХУВАЛЗ 1. а м ь т а н үр олсон эм хачиг; **хачиг хувалз** х о р ш.; 2. ш и л ж с э н мөлжигч.

ХУВАНЦАР хувтай адилавтар бүрмэл эд, шахах, цутгах зэргээр янз бүрийн юм хийж болно; *хуванцар эдлэл.*

ХУВГАР хув, хулгар; *хувгар хонь; хувгар чих.*

ХУВДАХ хувцас хунарыг нарийн моголцог эмжиж чимхэх.

ХУВИАР I 1. юмыг хувааж салгасан хувь; *ажлын хувиар; орлого зарлагын хувиар;* **цагийн хувиар** (а. хэдэн цагт юу хийхийг төсөвлөн зохиосны нь; *цагийн хувиарыг хатуу баримтлан тогтмол ажиллах;* б. цагийн дотор цаг, минут, секундийн хувь, зураас); 2. ш и л ж с э н томилолт; *их сургууль төгсөгчдийн хувиар.*

ХУВИАР II тариалан хадлангийн газрын галбайн хэмжээний нэр, нэг зуун үр буюу гучин зургаан мянган дөрвөлжин алд газар; *нэг хувиар газар тариа тарьсан.*

ХУВИАРЛАГДАХ хувиарлахын үйлдэгдэх хэв.

ХУВИАРЛАГЧ хувиарлах үүрэг бүхий юм; *бараа хувиарлагч; машинын хувиарлагч гол.*

ХУВИАРЛАЛ хувиарлалт.

ХУВИАРЛАЛТ хувиарлах үйлийн нэр хувиарлал; хувиарлалт хийх.

ХУВИАРЛАХ 1. хуваах; *тариалангийн газрыг хувиарлах; албан татвар ногдуулан хувиарлах;* 2. томилох; *боловсон хүчнийг зөв хувиарлах; сургууль төгсөгчдийг хаа чухал хэрэгцээтэй газар хувиарлах хэрэгтэй.*

ХУВИАРЛУУЛАХ 1. хувиарлахын үйлдүүлэх хэв; 2. хувиарлагдах.

ХУВИГҮЙ 1. ногдох юмгүй; 2. аз заяагүй, золбоогүй, үзэмжгүй; *би сайн явах хувигүй хүн биш билээ.*

ХУВИЙН нийгмийн биш, улсын биш, аминд ногдох: **хувийн өмч** (хүний амины өмч, өөрт нь оногдох өмч); **хувийн хэрэг** (а. албаны биш амины хэрэг явдал; *хувийн хэргээр хөдөө явах;* б. хүний зан байдал, ажилласан тодорхойлолт зэрэг тухайн хүнд холбогдох хэрэглэгдэхүүн сэлт); **хувийн аж ахуй** (аминд оногдох, амины мэдлийн аж ахуй); **хувийн аж ахуйтан** (нэгдэл, хамтрал зэрэгт ороогүй, амины аж ахуйгаар амьдрагсад); **хувийн жин** (тухайн биеийн жинг мөн хэмжээний жинтэй бөгөөд Цельсийн дөрвөн градус усны жинтэй харьцуулсан жин).

ХУВИЛАХ I 1. хувь болгох, хувааж ногдуулах; *хувилж өгөх;* 2. олон хувь болгох; *бичиг хувилах;* 3. тоог хувиар бодож гаргах, илэрхийлэх.

ХУВИЛАХ II юмны өөр болж хувирах; *зан суртал хувилах; өнгө зүс хувилах;* **хувилахуй ухаан** (хими).

ХУВИЛАХ III яр шарх зэрэгт буртаг бохирын зүйл орсноос болж цочрон өвдөх.

ХУВИЛГААН I хувирах, хувилахы нь.

ХУВИЛГААН II ш а ш и н юманд хувилж чаддаг чадал бүхий зүйл; *бурхны хувилгаан; тэнгэрийн хувилгаан;* **хувилгаан эм** (маш чадалтай сайн эм).

ХУВИЛГАДАС бат тогтворгүй, шийдвэргүй, буцамтгай; *хувилгадастай хүн.*

ХУВИЛГАХ I хувилуулах, хувилахад хүргүүлэх.

ХУВИЛГАХ II өөр болгох; *царайгаа хувилгах.*

ХУВИЛЗГАНА а м ь т а н хувалз.

ХУВИЛУУЛАХ I хуваалгах, хувь болгуулах.

ХУВИЛУУЛАХ II хувилахын үйлдүүлэх хэв; *байдлаа хувилуулах.*

ХУВИЛУУЛАХ III хувилах III-ын үйлдүүлэх хэв; *хадаасанд урсан газраа цэвэрлэхгүй явсаар байгаад хувилуулах бий дээ.*

ХУВИН шингэн юм агуулах нэг зүйл сав; *усны хувин; саалийн хувин.*

ХУВИРАЛ хувирах үйлийн нэр.

ХУВИРАМТГАЙ хувирамхай.

ХУВИРАМХАЙ хувирахад хялбар, хувирамтгай.

ХУВИРАХ аяндаа хувьсах, хувилж өөр болох; *зан аашь нь хувирах; өнгө зүс нь хувирах; хувирах чанар.*

ХУВИРГАХ хувируулах, хувирахад хүргүүлэх.

ХУВИРУУЛАХ хувирахын үйлдүүлэх хэв.

ХУВРАГ шашны ёсны лам; **лам хувраг** х о р ш.; *бурсан хувраг; ариун хувраг; тойн хувраг.*

ХУВХАЙ 1. юмны амь чийг тосны зүйлгүй болж он удаж хөсөр болсны нь, өгөр; *хувхай мод; хувхай яс;* 2. ш и л ж с э н хөрийн цагаан өнгөтэй болсны нь, зэвхий; *царай нь хувхай болсон байна; хувхай цагаан;* 3. ш и л ж с э н хоосон, нүцгэн, мод ургамал байхгүй; *хувхай дов; хувхай царай гаргах; хувхай газар.*

ХУВХАЙРАХ 1. хувхай болох; 2. ш и л ж с э н хоосрох, үгүйрэх.

ХУВХАЙРУУЛАХ хувхайрахын үйлдүүлэх хэв.

ХУВХАЙТАХ хувхай царай гаргах.

ХУВХАЙШРАХ хувхай шинжтэй болох.

ХУВЦАД хувцас; *дээл хувцад.*

ХУВЦАС хүний биед өмсч хэрэглэх эдлэлийн нэр; **хувцас хунар** х о р ш.; *ажлын хувцас; албаны хувцас; дулаан хувцас; өвлийн хувцас; ёслолын хувцас; дотуур хувцас; хувцас өмсөх; хувцасны өлгүүр; хувцас тайлах газар;* **хувцсаа буруулах** (хувцсаа сольж өмсөх).

ХУВЦАСЖИХ хувцас сайтай болох.

ХУВЦАСЖУУЛАХ хувцасжихийн үйлдүүлэх хэв.

ХУВЦАСЛАХ 1. хувцсаа өмсөх; *түргэн хувцаслах;* 2. хувцастай болох; *энэ хэдэн хүүхдийг хөдөө гэрийхэн хувцаслаж байгаа юм.*

ХУВЦАСЛУУЛАХ хувцаслахын үйлдүүлэх хэв.

ХУВЦАСЧИН хувцас хийдэг хүн, хувцас засварчин.

ХУВЦЛАХ дээл хувцсаа өмсөх, бүрэн хувцастай болох; *би ч биеэ өвч хувцалж авав;* **хувцлах толь** (хувцас хунар өмсөхөд биеэ харах том толь).

ХУВЬ I цагийн хэм, нэг мөчийг арван тав хуваасны нэг, минут.

ХУВЬ II өв, хөрөнгө: **өв хувь, өмч хувь, хувь ногдол** х о р ш.; *хувь нийлэх; хувь нийлүүлэн хорших; хувьд нь олгох юм; хувьдаа завших;* **хувиа бодох** (амиа бодох, зөвхөн өөрийгөө бодох).

ХУВЬ III юмыг хуваагаад ногдох хэсэг; *зуу хуваасны нэг хувь;* **хувь өгөх** (өв юм олгох); **хувь адил** (хуваах юмны тэнцүүгий нь, тэн адил); **хувь илүү** (юмыг хуваасны нэгний ногдол нөгөөгийн ногдлыг хоёр давхарласанд хүрэх хэмжээ).

ХУВЬ IV заяа, зохиол, аз; **хувь заяа, аз хувь** х о р ш.; **хувь зохиол** (ногдсон нь, заяасан нь); **хувь дутуу** (а. нэг хувь бага буюу наана болсныг нь; б. заяа мөхөс дутмаг болсны нь): **хувь дутах** (заяа дутуу болох, аз дутах); **хувь татах** (хүний зүс царай буурч муухай болох, жавхаа цог хий морь нь доройтох).

ХУВЬ V зарим олон ижил юмны тусгай нэгийг нь; *олон хувь ном; нэг мянган хувь хэвлэсэн.*

ХУВЬСАЛ хувьсах үйлийн нэр; *тооны хувьсал; чанарын хувьсал.*

ХУВЬСАЛТ хувьссан нь, хувьсал бүхий.

ХУВЬСАХ 1. урьдахаас өөрчлөгдөн хувилах, хувирах; *ажил явдал нь хувьсах; зан аашь нь хувьсах; цаг төрийн байдал хувьсах;* 2. хувьсгалжих.

ХУВЬСГАЛ 1. эсрэг тэсрэг ангит нийгэмд болох нийгэм-улс төрийн харьцааны үндсэн эргэлт бөгөөд үйлдвэрлэх хүчин үйлдвэрлэлийн харьцаа хоёрын хоорондын зөрчлийг хүчирхийллийн замаар шийдвэрлэж, төрийн эрхийг нийгмийн тэргүүний анги булааж авах эргэлт; *Октябрийн нийгэм журамт их хувьсгал; ардын хувьсгал; үндэсний эрх чөлөөний хувьсгал; хувьсгалын өмнөх үе; хувьсгалын эсэргүү;* 2. үйлдвэр зэрэг ямар нэг салбарт гарах үндсэн эргэлт; *техникийн хувьсгал; соёлын хувьсгал.*

ХУВЬСГАЛТ 1. хувьсгалын үзэл санаа бүхий, хувьсгалын хөдөлгөөнд холбогдол бүхий; *хувьсгалт хөдөлгөөн; хувьсгалт цэрэг; Монгол Ардын Хувьсгалт Нам;* 2. хувьсгалаар тогтоогдсон, амжилт бүхий; *хувьсгалт хууль.*

ХУВЬСГАЛЧ хувьсгалын онол ухааныг хэлбэршгүй баримтлан дэлгэрүүлэх ба тэр үйл хэрэгт бүцалт няцалтгүй зүтгэгч хүн.

ХУВЬСГАХ хувьсуулах, хувьсахад хүргүүлэх.

ХУВЬТАЙ заяатай, золбоотой, үзэмжтэй, жавхаатай; *хувьтай хүн; хувьтай эд.*

ХУГА хүч нэмэгдүүлэх үг; *хуга цохох; хуга татах; хуга дарах.*

ХУГАЛАХ хугарахад хүргүүлэх; **нэр хугалах** (нэр гутаах); **урмы нь хугалах** (урам зоригий нь мохоох).

ХУГАЛУУЛАХ 1. хугалахын үйлдүүлэх хэв; 2. хугалагдах.

ХУГАРАЛ хугарах үйлийн нэр, нугарал; **гэрлийн хугарал** (гэрлийн чиг өөрчлөгдөх, үзэгдэл, гэрлийн хугарлыг хараа-зүйн багажинд ашиглана).

ХУГАРАЛТ хугарах үйлийн нэр, хугарсан нь.

ХУГАРАМТГАЙ хугарахдаа маш хялбар.

ХУГАРАХ I. хатуу юмны огцрон гэмтэх, салах; *уурга хугарах; хөл хугарах; мод хугарах чимээ сонсдов;* 2. санаа зориг мохож шууд няцах; *урмас хугарах; зориг хугарах;* 3. муудах, гутах; *нэр хугарахаар яс хугар.*

ХУГАРУУЛАХ хугарахын үйлдүүлэх хэв, хугалах.

ХУГАРХАЙ хугарсны нь, хугарсны хэсэг; *хугархай мод; модны хугархай; хугархай гар; хөрөөний хугархай.*

ХУГАЦАА үйл ажилд өдөр хоног цаг болзож хэмжээлсэн хэмжээ; **хугацаа хэмжээ** х о р ш.; *хугацаа тогтоох; хугацаа сунгах; хугацаа тавих; хугацаа хэтрэх; түр хугацаагаар; хугацаатай хоног; нэг сарын хугацаа.*

ХУГАЦААГҮЙ тогтоосон хугацаа хэмжээ заагаагүй.

ХУГАЦАХ I хугацаа тогтоож өгөх; *хоног хугацаж ажиллуулах хэрэгтэй.*

ХУГАЦАХ II хөнгөтгөх, хэлтрүүлэх; *ял хугацах; татвар хугацах.*

ХУГАЦУУЛАХ 1. хугацахын үйлдүүлэх хэв; 2. хугацагдах.

ХУГАЧИХ байн байн хугалах.

ХУГАЧУУЛАХ хугачихын үйлдүүлэх хэв.

ХУД эр эм бололцогсдын охины төрхмийн этгээдэд түүний хүргэний төрлийн хүмүүс; **худ худгуй** (худ бололцсон хүмүүс); **худ анд** (худ худгуй); **худ овог** (өөр өвгийн ураг удам).

ХУДАГ газрыг эрж гаргасан устай нүх; *устай худаг; хуурай худаг; хашаатай худаг; өрөмдмөл худаг; сэнстэй худаг; худаг гаргах; худаг ухах; худаг малтах; худгийн усанд загасгүй, хуурай модонд навчгүй* з ү й р; **худаг лайдах** (худгийн доторхи хог шороо зэрэг буртгийг арилган цэвэрлэх); **худаг харьдах** (худаг лайдах): **худгийн хашилга** (худгийн дотоодод чулуу модоор барьсан хашлага); **худгийн соруул** (худгийн усыг сорж гаргах зэвсэг).

ХУДАГЖИХ худаг элбэгтэй болох.

ХУДАГЖУУЛАХ худагжихын үйлдүүлэх хэв.

ХУДАГЛАХ худаг шиг ухах; *нүх худаглаж ухах.*

ХУДАЛ үнэнгүй, хуурамч; *худал үг; худал хэлэх; худал үнших;* **худал хуумгай** (лавтлалтай үнэнийг мэдэж хянахгүй наагуурдан хэлэлцэхий нь); **худал хуурмаг** (худал үг зохион хуурмаглан хэлэх, хуурах); **худал ташаа** (худал хуурмаг буруу); **худал зэхий** (худал хуумгай); *худал хойноо, хусран хавартаа* с э ц э н.

ХУДАЛДАА (Н) юмыг үнэ өртөгтэйгөөр харилцан өгч авах явдал; **худалдаа наймаа** х о р ш.; *улсын худалдаа; хувийн худалдаа;*

ногооны худалдаа; **үүргийн худалдаа** (хэрэгцээний юмыг хот суурин газар авч явж зарах наймаа); **ганзагын худалдаа** (хэрэгцээний юмыг хөдөө айлуудаар авч явж зарах наймаа); **дамын худалдаа** (ашиг хонжоо олохыг хичээж үнэ хэтрүүлэн худалдах, наймаа): **гадаад худалдаа** (гадаадын улс гүрэнтэй хийх наймаа; *гадаад худалдааны яам);* **худалдаа бэлтгэл** (худалдаалах мал юм, түүхий эдийн зүйл); **худалдаа хийх** (худалдааны үйл хийх); **худалдаа гүйлгээ** (худалдааны эд юмыг хувилгаж дамжуулахы нь); **худалдааны хүн** (худалдаагаар голлож аж төрөх хүн); **худалдааны газар** (худалдаа хийх ажлыг эрхлэн явуулах газар; *хоршоо худалдааны газар; хувийн худалдааны газар; худалдааны яам);* худалдааны **гэр** (пүүс, дэлгүүр).

ХУДАЛДААЛАХ худалдаа хийх; *мах ногоо худалдаалах; архи худалдаалах; зууш худалдаалах газар.*

ХУДАЛДААЧ худалдаагаар голлож амьдрах хүн.

ХУДАЛДААЧИН худалдаа **хийгч** хүмүүс; *дамын худалдаачин.*

ХУДАЛДААЧЛАХ хэсүүчлэн явж худалдаа хийх.

ХУДАЛДАГЧ худалдаа хийх газрын юмыг эрхлэн худалдах хүн; *төв дэлгүүрийн худалдагч.*

ХУДАЛДАХ үнэ авч арилжин өгөх; *ангийн үс худалдах; цагаан идээ худалдах; худалдан авагч;* **худалдан авах** (үнэ өгч арилжин авах морь мал, эд юм худалдан авах); **худалдан авах чадвар** (аливаа юмыг худалдан авах боломж, бололцоо; *ард түмний худалдан авах чадвар ихэд өссөн байна);* **биеэ худалдах** (а. янхан болох; б. ашиг хичээн бусдад урвах).

ХУДАЛДУУЛАХ 1. худалдахын үйлдүүлэх хэв; 2. худалдагдах.

ХУДАЛЧ худал хэлдэг хүн; *худалч хүний үгэнд бүү итгэ; худалч хүн хойноо муу;* ***хусран гүү хавартаа муу*** з ү й р.

ХУДАЛЧДАХ дэндүү худалч болох.

ХУДАР а м ь т а н цулбуурт ахиа загастай төстэй нэгэн зүйл загас, элэг нь маш эрхэм хэдэг.

ХУДГУЙ эр эм бололцогсдын хүргэний төрлийн этгээдэд түүний бэрийн төрлийн хүмүүс.

ХУДЛАХ харилцан ураг бололцох.

ХУДРАГА I 1. эмээлийн хавтасны хойт этгээдэд уяж морь малын сүүл бөгсөнд торгож бэхлэх оосор; **хазаар худрага** х о р ш.: 2. ш и л ж с э н явсан зорчсоны хойгуур бөгсөөр; *хүний явсан худрагаар сууж хоцорсон гөрөөс; миний одсоны худрагаар тэр хүн ирж билээ.*

ХУДРАГА II нумны заадасны хоёр этгээдийн говил газры нь.

ХУДРАГАГҮЙ 1. худрага байхгүй; 2. ш и л ж с э н аливаа хүнгүй болчимгүй, итгэлтэй бус; *худрагагүй хүн байж билээ.*

ХУДРАГАЛАХ I 1. эмээлтэй моринд худрага торгож хийх; 2. ш и л ж с э н худрагаар суух, бөгсөөр суух, хойш суух.

ХУДРАГАЛАХ II нумны хичрийн заадсанд говил гаргах.

ХУЖГАР өнгө, зүс царай муутай, хуржгар ч гэнэ; *хужгар царай; хужгар муу өнгөтэй эд.*

ХУЖИГНАХ юмны хур хийж дуугарах; *гэдэс хужигнах.*

ХУЖИГНУУЛАХ хужигнахын үйлдүүлэх хэв.

ХУЖИЙЛГАХ хужийхын үйлдүүлэх хэв, хужгар болгох.

ХУЖИЙХ хужгар болох; *царай нь хужийгаад бие чинь зүгээр үү?*

ХУЖИР 1. хээр газар ургадаг шүлтэрхэг талст бодис, өнгө цагаан; **хужир мараа** х о р ш.; *хужиртай газар; хужиртай хөрс тариаланд зохимжгүй;* **малын хужир** (мал иддэг хужир); **амны хужир** (хүн иддэг хужир); **шороон хужир, мөсөн хужир** (шахмал хужир); **хужир ургах** (а. газраас хужир гарах; б. юманд хужир мэт юм бий болж тогтох); **хужир даах** (а. хужир ургах; б. юмны өнгө зүс хужир мэт зэвхий болох): 2. ш и л ж с э н хамгийн дуртай идэш уушны зүйл; *дарш чинь малын хужир нь байгаа юм.*

ХУЖИРЛАХ малд хужир өгөх, идүүлэх; *хонь хужирлах; хужир идэж хужирсаагаа тайлах;* **нүд хужирлах** (үзээгүй буюу үзэх гэж хүссэн юмаа үзэж сэтгэл ханах).

ХУЖИРЛУУЛАХ хужирлахын үйлдүүлэх хэв.

ХУЖИРСАА хужирсах үйлийн нэр, хужир хүсэх хүсэл; *малын хужирсааг гаргах.*

ХУЖИРСАХ 1. мал гөрөөсний зэрэг амьтны хужир хүсэх, *хонь хужирсаж байна;* 2. шилжсэн юманд сонирхон шунаж дурлах; *хужирссан юм шиг ухаан жолоогүй зүтгэлэв.*

ХУЖИРСУУЛАХ хужирсахын үйлдүүлэх хэв.

ХУЖИРТАЙ хужир бүхий; *хужиртай газар.*

ХУЖИРТАХ хужир ургах байдал гарах.

ХУЖИРХАЙ гүзээтэй амьтны гүзээний нугалбарын зузаан газар.

ХУЗГАЙ: хазгай хузгай хазгай; *хазгай хузгай гишгээд л гүйв; хазгай хузгай ярих дуртай.*

ХУЙ I юм хум агуулах гэр сав; *хутга сэлэмний хуй; бууны хуй; бичгийн хуй.*

ХУЙ II ямагт эргэн мушгирч хоролзон нөөлгөлөх салхи; *хуй салхи; хуй босох; элсэн хуй; цасан хуй; хуй салхи шиг хурдан.*

ХУЙ III бүхэл толгой, бүхэл хуйлаас; *хуй торго; хуй дурдан; хуй цаас.*

ХУЙ IV: **хурал хуй** хурал; *энэ өдөр хурал хуйтай юу?* **хуйн хурал** (өртөөний хурал, жалгын хурал мэтийн хөдөөний бага сага газрын цаг цагийн хурал).

ХУЙ V зэвэг загасны зүлзага; **хуй алаг нугас** амьтан (толгой нугастай адил болоод цагаан эрээн нэгэн зүйл шувуу); **хуй булаг нугас** амьтан (хуй алаг нугастай адил болоод эрээн нэгэн зүйл шувуу); **хуй шаазгай** амьтан (шаазгайтай адил, үнсэн өнгөтэй, урт сүүлтэй нэгэн зүйл шувуу).

ХУЙВ ууранд уях оосор; *уураны хуйв; гурын хүзүүгээр хийсэн хуйв.*

ХУЙВАЛДААН нууц сүлбээ; *хуйвалдаан хийх.*

ХУЙВАЛДАГЧ хуйвалдсан этгээд.

ХУЙВАЛДАХ сэм саная зохицон нам нийлэх; сүлбээлэх; *нам нийлж сэм хуйвалдах; эзэрхэг түрэмгийчүүд ямагт хуйвалдаж байдгийг бид эс мэдэх биш.*

ХУЙВАЛДУУЛАХ хуйвалдахын үйлдүүлэх хэв.

ХУЙВЛАХ ууранд хуйв уях.

ХУЙВЛУУЛАХ хуйвлахын үйлдүүлэх хэв.

ХУЙГУУР зусар; **хуйгуур зусар** хорш..

ХУЙГУУРЛАХ зусарлах, бялдуучлах.

ХУЙЛАА хуйлаас; *хуйлаа нь сулдаж байна; хуйлаатай торго.*

ХУЙЛААС хуйлж ороосон юм, хуйлаа; *хуйлаастай цаас.*

ХУЙЛАХ I юмыг хуйд дүрэх, хийх, хуйтай болгох.

ХУЙЛАХ II нимгэн юмыг нэгэн этгээдээс ороож эвхэх; *цаас хуйлах; эд бараа хуйлах.*

ХУЙЛАХ III цуглах, нэгдэх, бөөгнөрөх.

ХУЙЛМАГ хуйлж ороож хийсэн зүйл; *хуйлмаг бин; байцааны хуйлмаг.*

ХУЙЛМАЛ хуйлсны нь; *хуйлмал хэмжүүр; хуйлмал зураг.*

ХУЙЛРАХ 1. атирах, эвхрэх; *цаас хуйлрах; даавуу хуйлрах;* 2. бөөгнөрөх, ханарах; *тоос хуйлрах; хонь мал хуйларч зогсох.*

ХУЙЛРУУЛАХ хуйлрахын үйлдүүлэх хэв.

ХУЙЛУУЛАХ I хуйлах I-II-ын үйлдүүлэх хэв.

ХУЙЛУУЛАХ II хуйлах III-ын үйлдүүлэх хэв; цуглуулах, нэгтгэн эмхтгэх; *мал аж ахуйн тухай гарсан тогтоол зааврыг хуйлуулан нэг эмхтгэл гаргав.*

ХУЙМАГ гуриныг шингэн зуурч буцламгай тосонд хайран болгож хийдэг нэгэн зүйл идээ; *хуймаг хайрах; хуймаг хийх; хуймаг идэх.*

ХУЙРАГ ургамал говь газар зэллэж ургана, дурс бор, жижигхэн хар ногоон навчтай нэгэн зүйл ургамал.

ХУЙСАЛЗАХ 1. хүний ундууцан муухай аашлах; *хоёр ааш нь хөдөлжээ, хуйсалзаад байна;* 2. салхи шороо зэрэг үймцэж тэнгэрийн байдал аягүй муухай болох; *тэнгэр хуйсалзах.*

ХУЙСГАНАХ хуйсалзах, аягүй аашлах байдал гаргах.

ХУЙСГАР өнгө царай муухай; *тэнгэрийн царай хуйсгар байна, салхи гарч магадгүй; бие чинь зүгээр үү? царай чинь хуйсгар байна.*

ХУЙСРАХ муухай зан гаргах, хуйсгар болох; *тэнгэр хуйсрах.*

ХУЙСЧИХ байн байн хуйсрах.

ХУЙСЧУУР муухай аашлах зантай; *хуйсчуур хүний аюул даа.*

ХУЙХ 1. арьс буюу арьст юмны үсий нь түлж арилгасан хөрс; *толгойн хуйх; өвчүүний хуйх;* 2. сор нь унасан үст юмны уг үлдэгдэл; *халиуны хуйхан малгай; хуйх болсон минжин нудрага;* 3. толгойн арьс; *хуйх өвдөж байна; хуйх нь язарчихжээ.*

ХУЙХАЙ салхай, задгай.

ХУЙХАЛЗАХ муухай зан ааш гаргах.

ХУЙХАРЛАХ хирээс хэтэрхий авир гаргах.

ХУЙХЛАХ 1. арьс мах зүйлийн үс ноосыг түлж огцруулах; *шийр толгой хуйхлах; өвчүү хуйхлах;* 2. ширүүн догшин зан авир гаргах; *хуйхлах гэсэн сүрхий зантай хүн шүү.*

ХУЙХЛУУЛАХ хуйхлахын үйлдүүлэх хэв.

ХУЙХУЙ I хотон аймаг; **хуйхуй хотон** х о р ш.

ХУЙХУЙ II дүрсгүй зан байдалтай; *хуйхуй шиг амьтан.*

ХУЙХУЙТАХ дүрсгүйтэх, дүрсгүй зан авир гаргах; *чи битгий хуйхуйтаад байгаач.*

ХУЛ I хулуу.

ХУЛ II хумбан хэлбэртэй томоохон модон аяга; *айргийн хул.*

***ХУЛ** III 1. адууны нэгэн зүйл зүсэм, хонгор зүсэмтэй ойролцоо, шаравтархан бөгөөд баахан бүдэх, их төлөв дэл сүүл нь бараавтар байдаг; *хар хул; шар хул; ганган хулыгаа унаж явлаа, Гандангийн үүдээр галгиулж явлаа хөө хөө* (ардын дуу); 2. улбардуу бор шар өнгө; *хул шар торго.*

ХУЛАГ а м ь т а н чоно мэт, том биетэй, илбэрсэн хар үстэй, маш ховдог учир гэдсээ цагтайтал идээд ой шугуйд орж модны завсар хавчуулан хэвтэж хоолоо шингээдэг нэгэн зүйл амьтан.

ХУЛАГЧ хул зүсмийн эм мал; *хулагч үүү.*

ХУЛАЙЛГАХ хулайхын үйлдүүлэх хэв, хулгар болгох.

ХУЛАЙХ хулгар болох, хулгар амьтны байх байдал.

ХУЛАЛЗАХ 1. хулгар амьтны хөдлөх ааш-лах; 2. хүн амьтны гэмшиж хялмалзан байгаа байдал гарах, хулмалзах ч гэнэ; **хулалзах хялалзах** х о р ш.

ХУЛАМГАНАХ хулмалзах, хулалзах.

ХУЛАМГАНУУЛАХ хуламганахын үйлдүүлэх хэв.

ХУЛАН I а м ь т а н луусын ойролцоо, цагаан хонгор зүстэй нэгэн зүйл адуу, чихтэй ч гэдэг: **хулан чихтэй** х о р ш.; **хулан жороо** а м ь т а н (таргалжтай адил боловч өнгө хөхөвтөр нэг зүйл шувуу, их хурдан явдаг гэнэ); **хулан гуа** у р г а м а л (дүн гуатай адил хэлбэртэй, арай нарийн урт, өнгө ногоон гуа).

ХУЛАН II зуухны утаа гарах нүх, **хүхээ** ч гэнэ.

ХУЛАН III элэн, юмны чимээ анир хөл үймээнгүй нам гүмий нь; **элэн хулан** х о р ш.; *элэн хулан өдөр; элэн хулан газар.*

ХУЛАНС I хулмас.

ХУЛАНС II адууны хөлийн дотор этгээдэд ургасан жижигхэн эвэрлэг зүйл.

ХУЛАНЦ элэнц өвөг эмгийн эцэг эх; **элэнц хуланц** х о р ш.; *хуланц өвөг; хуланц эмэг; хуланц эцэг; хуланц эх.*

ХУЛАНЦАГ элэнцэг өвөг эмгийн эцэг эх; **элэнцэг хуланцаг** х о р ш.; *хуланцаг өвөг; хуланцаг эмэг; хуланцаг эцэг; хуланцаг эх.*

ХУЛБАЙ гайхах, сэжиглэх аялга, урьд сонсоогүй мэдээгүй, үзээгүй юмыг асуухад гайхсанаа илтгэхэд хэрэглэнэ; *хулбай, ямар юм бол доо; хулбай, би мэдэхгүй юм.*

ХУЛГА I 1. гэмшиж гаслахад хэрэглэх аялга; *халаг, аа хулга мэдсэн ч болоосой, сурсан ч болоосой!* 2. зүгээр дэмий; *аа хулга, өнжив; аа хулга, өнгөрөв.*

ХУЛГА II чихний дотоодоос гарах наалдаа зүйл; *хуурай хулга; нойтон хулга.*

ХУЛГАВЧ эхнэр хүний өмсөх зөвхөн чих, хацар халхлах оройгүй малгай.

ХУЛГАВЧЛАХ хулгавч өмсөх бас малгайг эрүүвчлэх; *малгайгаа хулгавчил!*

ХУЛГАВЧЛУУЛАХ хулгавчлахын үйлдүүлэх хэв.

ХУЛГАЙ 1. амины болон улс нийгмийн өмч хөрөнгө, эд юмыг нууж авах, жигшүүрт явдал; **хулгай дээрэм, хулгай худал, хулгай зэлгий** х о р ш.; **хулгай хийх** (амины болон улс нийгмийн эд хөрөнгийг сэмхнээр нууж авах); **хулгай мэдэгдэх, хулгай баригдах** (нууж үйлдсэн хулгайн гэмт үйл явдал илрэх); **хулгай сэ-**

рэх, хулгай сэрдэх (алдсан юмаа чи авсан гэж бусдыг сэжиглэн сэрдэх): **хулгай авах** (хулгайч авах, хулгайд алдах); **хулгайн хэрэг** (хулгайн гэмт явдал); **хулгайн үүр** (хулгайн орших хоргодох газар); **хулгайн уяа** (хулуусан малыг уях нууц газар); **хулгайгаар ирэх** (нууцгай ирэх); **хулгай зам** (сайн ажиглахгүй бол мэдэгдэхгүй бүдэх жим зам); ☆ **хулгай гэзэг** (толгойн хонхор шилний дээдхэн хэсэг газар); **хулгай нүдээр харах** (бусдад анхаарагдахгүйгээр нууж харах): 2. урваж тэрсэлсэн этгээд; *урвасан хулгай; тэрсэлсэн дээрэмчин; урвасан хулгай Найдан ванг уухай хийгээд дарав аа хөө* (ардын дуу). ᠬᠤᠯᠭᠠᠶ

ХУЛГАЙЛАХ амины болон улс нийгмийн өмч хөрөнгө, эд юмыг сэмээр нууж авах, хулуух, хулгай хийх. ᠬᠤᠯᠭᠠᠶᠯᠠᠬᠤ

ХУЛГАЙЛУУЛАХ 1. хулгайлахын үйлдүүлэх хэв; 2. хулгайлагдах. ᠬᠤᠯᠭᠠᠶᠯᠠᠭᠳᠠᠬᠤ

ХУЛГАЙЧ I яваг шар шувуу. ᠬᠤᠯᠭᠠᠶᠴᠢ

ХУЛГАЙЧ II хулгай хийдэг хүн амьтан; *хулгайч хүн; хулгайч муур; хулгана хулмалзана, хулгайч гөлбөлзөнө* з ү й р.

ХУЛГАЛЗАХ 1. хүний тогтуургүй урвалхидах; 2. морь малын айж зайлсхийн аашлах. ᠬᠤᠯᠭᠠᠯᠵᠠᠬᠤ

ХУЛГАНА а м ь т а н 1. шишнүүхэй оготнын язгуурт багтдаг, уртлаг хушуутай, сүүл нарийн нэг зүйл мэрэгч амьтан; *хулганын занга; хулганын хавх;* **хулганын орд** (хулганын орших нүх); **мэхээрийн хулгана** а м ь т а н (хулганын намын нэгэн зүйл жижигхэн хулгана, сүүл маш богино, мэхээр хурааж нөөцлөн иддэг); **атаахай хулгана** а м ь т а н (хорт шавьжийг устгадаг нэгэн зүйл ашигтай хулгана, биеийн урт нь есөн сантиметр хүрнэ); **морин хулгана** а м ь т а н (хулганын намын нэгэн зүйл том хулгана); **хулгана яр** (а. хүний биед гарах нэгэн зүйл хорт яр өвчин; б. адуунд дамжин халдварлах бөгөөд анх хүзүүний орчмоос эхлэн гарч үрэвсэн хордуулах нэгэн зүйл яр өвчин); **хулганын тос** у р г а м а л (хээрийн ногоо, ишгүй, ганц навчтай, амт тогтуусны адил, голын ойр шугуйд ургана, дарж иднэ): 2. сарны зурхайн ёсны жил сар, өдөр цаг ээлжлэн эзлэх арван хоёр эрхтний нэгийн нэр; *хулгана жил; морин цаг;* ☆ **усан хулгана болох** (маш их хөлрөх, маш их норох). ᠬᠤᠯᠭᠠᠨᠠ ᠭ

ХУЛГАНАХ байн байн хулгах. ᠬᠤᠯᠭᠠᠨᠠᠬᠤ

ХУЛГАР 1. амьтны чих хэвийн жишээнээс бага буюу чихгүйг нь; *хулгар чихтэй хурга;* 2. тарваганы өөр нэр; *хулгарын мах иддэг үү?*

ХУЛГАХ 1. хүний бие тогтвортой сууж чадахгүй ийш тийш хөдлөх; 2. бусдын хэлсэн үгний хариуг хэлэхгүй түүдрэх, татгалзах; 3. морь малын хулгалзах байдал гаргах; 4. юмнаас бэрхшээх байдал гаргах; 5. чихтэй малгай бүчилж өмсөх; *юүдэн хулгаж өмсөх.* ᠬᠤᠯᠭᠠᠬᠤ

ХУЛГУУ хадаасны толгойг дүгрэг болгох зэрэгт хэрэглэх нүхтэй төмөрлөг багаж. ᠬᠤᠯᠭᠤᠤ

ХУЛГУУЛАХ 1. хулгуухын үйлдүүлэх хэв; 2. хулгуугдах. ᠬᠤᠯᠭᠤᠤᠯᠭᠠᠬᠤ

ХУЛГУУХ хүний эд юмыг сэмээр нууж авах, хулуух, хулгайлах. ᠬᠤᠯᠭᠤᠤᠬᠤ

ХУЛДААС элдэв эдлэл хэрэглэлийг өнгөлөн бүрхэх хулдахад зориулсан эд; *ширээний хулдаас; шалны хулдаас.* ᠬᠤᠯᠳᠠᠠᠰᠤ

ХУЛДААСЛАХ хулдах, хулдаасаар бүрэх, өнгөлөх. ᠬᠤᠯᠳᠠᠠᠰᠯᠠᠬᠤ

ХУЛДААСЛУУЛАХ хулдааслахын үйлдүүлэх хэв. ᠬᠤᠯᠳᠠᠠᠰᠯᠠᠭᠳᠠᠬᠤ

ХУЛДАХ юмыг хулдаас мэтээр бүрхэж өнгөлөх; *ширээ хулдах; шал хулдах; цаасаар хулдах.* ᠬᠤᠯᠳᠠᠬᠤ

ХУЛДУУЛАХ хулдахын үйлдүүлэх хэв. ᠬᠤᠯᠳᠤᠤᠯᠭᠠᠬᠤ

ХУЛЖААХ хулжихад хүргүүлэх, хулжуулах. ᠬᠤᠯᠵᠠᠠᠬᠤ

ХУЛЖИМГАЙ морь малын хулжих зантайгий нь, хулжимтгай ч гэнэ. ᠬᠤᠯᠵᠢᠮᠭᠠᠢ

ХУЛЖИМТГАЙ хулжимгай. ᠬᠤᠯᠵᠢᠮᠲᠭᠠᠢ

ХУЛЖИХ 1. амьтны айж жигшин зугадаж зайлах, буруулах; *морь хулжих;* 2. ш и л ж с э н өтөг бууцны хэвгий тийшээ нурж шилжих; *бууц хулжих;* 3. ш и л ж с э н нойр хүрэхгүй болох; *нойр хулжих.* ᠬᠤᠯᠵᠢᠬᠤ

ХУЛМАГАНАХ 1. бэмбэгнэх, хулгалзах, хулмалзах, хулчганах; *айж хулмаганаад байхын хэрэг алга;* 2. хулман амьтны хулмага хулмага хийх. ᠬᠤᠯᠮᠠᠭᠠᠨᠠᠬᠤ

ХУЛМАЙЛГАХ хулмайхад хүргүүлэх. ᠬᠤᠯᠮᠠᠢᠯᠭᠠᠬᠤ

ХУЛМАЙХ мал адгуусны чихээ гэдрэг матируулан дарах; *чихээ хулмайх.* ᠬᠤᠯᠮᠠᠢᠬᠤ

ХУЛМАЛЗАХ хулмаганах, хулман амьтны хулмас хулмас хийх. ᠬᠤᠯᠮᠠᠯᠵᠠᠬᠤ

ХУЛМАН амьтны чих жижиг, хулгардуугий нь; *хулман чихтэй хүрнээрээ, хөндий талыг гатлав.* ᠬᠤᠯᠮᠠᠨ

ХУЛМАС зарим хүний суганаас гарах гажуу муухай үнэртэй хөлс.

ХУЛС I у р г а м а л устай газарт ургадаг, өндөр, үетэй хөндий голтой нэгэн зүйл дэрс мэт өвс, чиг чийрс хийдэг: **хулсан сахал** (хулс гэдэг өвсний түрүү); **хулсан дээс** (хулс өвсөөр сүлжиж хийсэн дээс, далайн онгоц чирэхэд хэрэглэнэ).

ХУЛС (АН) II у р г а м а л иш шудрага, үе үеэр ургадаг, дотроо хөндий, урт навчтай нэгэн зүйл мод; **хулсан чигийрма цэцэг** у р г а м а л (хүйс эрхэм чигийрмагийн адил, өнгө хүрэн, үнэргүй нэгэн зүйл цэцэг); **хулсны ятуу** а м ь т а н (янз тахианы адил, өнгө хүрэн, бидэр ихтэй, хулсны шугуйд оршдог нэгэн зүйлийн шувуу); **хулсны хулгана** а м ь т а н (янз жижигхэн мууртай адил бөгөөд хулс модны угийг иддэг нэг зүйл амьтан); **хулсан шар** (хулс модны өнгөтэй төсөөтэй шар өнгө); **хулсны сүеэ** (хулс модны шинэ ургаж байгаа соёо, боловсруулан иднэ); **хулсан хуур** (хөгжмийн зэвсэг, хулсыг нимгэлэн зорж дунд нь хэл гарган, хоёр үзүүрт утас хэлхэж аманд тулгуулж, утаснаас таталхийлан дуугаргана, аман хуур, хэл хуур ч гэдэг); **хулсан цаас** (хулс модыг нунтаглан, усанд дэвтээж тунгаан хийсэн нэгэн зүйлийн цаас); **хулсан сувд** (хулс модонд ургадаг, байдал танын адил, хэлбэр асар бөөрөнхийгүй, өнгө нь бүдэх эд).

ХУЛСЛАГ 1. хулс ихтэй; 2. хулсархуу, хулс мэт; **хулслаг улаан цэгцүүхий** у р г а м а л (туурын цэцэгтэй адил, таван хэлтэстэй, өнгө цайвар улаавтар, навч хулс модны адил нэгэн зүйл цэцэг).

ХУЛСТ хулс бүхий; *хулст газар; хулст шугуй; хулст нуур.*

ХУЛТ: хулт бялзуухай а м ь т а н толгойдоо дугариглан ургасан цагаан чандартай нэгэн зүйл шувуу.

ХУЛУУ I хүн малын хөлд бэртэнгэ буюу шар ус хурж тогтсон бэлцрүү; **хулуу хуян, хулуу шар ус** х о р ш.; **хулуу хөдлөх** (хулуу нь өвдөх).

ХУЛУУ II у р г а м а л өнгө цагаавтар, янз бөөрөнхий зэрэг янз бүр бий, цангараагүй байхад нь буцалган идэж болно, бас зүрэмлэн хатааж иднэ, хальсаар нь хулан шанага зэргийг хийнэ: **дий хулуу** у р г а м а л (дун мэт хэлбэртэй нэгэн зүйл жижигхэн ногоо, гол төлөв давсалж иддэг).

ХУЛУУХ хулгай хийх, хулгайлах.

ХУЛХИ 1. амьтны чихний хэнгэрэг; *хулхи нь цоорох; хулхиа битгий хатгачихаарай; хулхиар нь буудах;* 2. чихний дотоодод хуралдсан хаг мэт юм; *хуурай хулхи; нойтон хулхи; хулхи ухах;* **хулхи нь буух** (а. чих нь буух; б. омог нь буурах, номгорох).

ХУЛХИДАХ хулхинаас барих, чихдэх; *эр хүн гэнэнгүй дээр гэж эцэн морио хулхидаж мордох* с э ц э н.

ХУЛХИТАХ 1. чихэнд хулхи тогтох; 2. хулхи өвчлөх.

ХУЛЧГАНАХ сэтгэл зовниж хулчийх, бэмбэгнэх.

ХУЛЧГАНУУЛАХ хулчганахын үйлдүүлэх хэв.

ХУЛЧГАР 1. аймхай, зүрх зориггүй; *аймхай хулчгар амьтан;* 2. тослог биш өнгө царайтай; *хулчгар цараан царайтай туранхай, өндөр нуруутай эр; хулчгар цараан гурил.*

ХУЛЧИЙЛГАХ хулчийхад хүргүүлэх, хулчгар болгох.

ХУЛЧИЙХ 1. хулчгар болох; *нүүр нь хулчийх;* 2. айх, зүрх зориг нь буурах; *чи хулчийж байна уу?*

ХУЛЧИЛЗАХ 1. хулчгар юмны хөдлөх байдал; 2. хулчганах.

ХУЛЧИН хулчгар; *хулчин цагаан; хулчин шар; хулчин ногоон.*

ХУМАГ сул шороо, өвс үс зэргийн хог; **хог хумаг, шороо хумаг** х о р ш.; **алтан хумаг** (юм будахад зориулж хийсэн алт мэт өнгөтэй нунтаг); **мөнгөн хумаг** (юм будахад зориулж хийсэн мөнгө мэт өнгөтэй нунтаг); **хумаг алт** (газраас гарсан хэвээр байгаа жижиг элсэн алт, шороон алт ч гэдэг).

ХУМАГТАХ тоос хумаг тогтох.

ХУМБАГАНАХ хумбагар юмны үргэлжлэн хөдлөх.

ХУМБАГАР 1. амсар нь гадагш дэрэвгэр биш, дотогш хөмгөр дүр хэлбэртэй юм, хумбан ч гэнэ; *хумбагар тогоо; хумбагар аяга;* 2. жижиг бондгор биетэй амьтан; *хумбагар хөврхөн хурга.*

ХУМБАЙЛГАХ хумбайхад хүргүүлэх, хумбагар болгох.

ХУМБАЙХ хумбагар болох, хумбагар харагдах.

ХУМБАЛЗАХ хумбагар юмны байн байн хөдлөх.

ХУМБАН хумбагар, цомбон; *хумбан шаазан; хумбан тогоо; хумбан туурай.*

ХУМБИХ хумих, хумхих, хураах; *шувуу жигүүрээ хумбих; дэлгэсэн тараасан юмаа татаж хумбих; хөлөө хумбих; хормойгоо хумбиж суух.*

ХУМЖАА I цахиур бууны дарь хэмжих сав.

ХУМЖАА II хумжаарга.

ХУМЖААРГА эмх цэгц; *хумжаргатай айл; хумжаарга муутай хүүхэд.*

ХУМЖААРГАДАХ хумжааргалах.

ХУМЖААРГАЛАХ юм хумыг хумжаргатай болгох, эмх замбараатай болгох, хураамжлах.

ХУМИГАР хумирсныг нь; *хумигар арьс шир; хумигар сав.*

ХУМИГДАХ хумихын үйлдэгдэх хэв.

ХУМИРАЛДАХ хумирахын үйлдэлдэх хэв.

ХУМИРАХ хумигар болох; *атирч хумирах; үрчийж хумирах.*

ХУМИРУУЛАХ 1. хумирахын үйлдүүлэх хэв; 2. хумирагдах.

ХУМИУЛАХ 1. хумихын үйлдүүлэх хэв, хумжааргалуулах; 2. хумигдах.

ХУМИХ боох, хумхих, цомтгох, цуглах, эмхлэх; **хураах хумих** х о р ш.; *ажлаа хумих; юм хумаа хумьж эмхтэй болгох;* **хөлөө хумих** (а. хөлөө татах; б. явах тэнүүчлэхээ зогсох); **амаа хумих** (дэмий олон юм үл өгүүлэх, амаа татах).

ХУМС (АН) амьтны хөл гарын хуруу, тавгийн өмнөх үзүүр дахь эвэрлэг зүйл; **хуруу хумс** х о р ш.; *гарын хумс; шувууны хумс;* **хумсны будаг** (хумс будах, өнгөлөх зүйл); **хумсын чинээ, хумсны чинээ** (маш бага гэж чамласнаа илэрхийлэхэд хэрэглэнэ; *хумсын чинээ хүүхэд; хумсын чинээ талхны хэлтэрхий);* **хумсыхан** (хумсын чинээн, жижигхэн, *ийм хумсыхан чинээн юмаар юу хийх вэ?);* **хумсан будаг цэцэг** у р г а м а л (нэг наст өвслөг ургамал, цэцэрлэг болон өрөө тасалгаанд тарьж болно); **эмгэн хумс** а м ь т а н (хэвэл хөлт, зөөлөн биетний ангид багтах амьтан, төрөл зүйл олон).

ХУМСЛАХ 1. хумсаар хатгах, чимхэх; 2. ш и л ж с э н бааханшийхэн хулуух; *хуурсаар хуурсаар худалч болох, хумсалсаар хумсалсаар хулгайч болох* с э ц э н.

ХУМСЛУУЛАХ хумслахын үйлдүүлэх хэв.

ХУМХ юм агуулах нэгэн зүйл сав, их төлөв амсар нь чухал, ёроол тал нь уужим хэлбэртэй сав, бумба ч гэнэ.

ХУМХАТ: хумхат цан цангийн адил болоод их багаараа пял мэт хэмжээтэй цан.

ХУМХАЧ хумх сав хийдэг мэргэжилтэй хүн.

ХУМХИ нарны гэрлийн туяанд үзэгдэх нарийн тоос; *хумхийн тоос; хумхийн наанги шороо; нарийн хумхи.*

ХУМХИХ хумих, хумбих, хураах; *дэлгэсэн тэнийлгэсэн юмыг хурааж хумхих; гар хөлөө хумхих; амаа хумхих; явдлаа хумхих; алчуураа хумхиж өвөртлөв.*

ХУН а м ь т а н цэнгэг усны эрэг орчим газраар үүрлэн орших үзэсгэлэнт сайхан, том шувуу, биеийн урт нь нэг зуун наян сантиметр орчим, хүнд нь арван гурван килограмм; *хун шувууны дэгдээхий, хулсан дундаа ганганаж байна* (ардын дуу).

ХУНАР дагавар аялга; **хувцас хунар, айл хунар** х о р ш.; *хувцас хунараа зас! айл хунараар битгий хэс!*

ХУНГАР салхи шуурганд хийсч хуралдан хатуурч хөрөлсөн цас; *хунгарт шигдэх.*

ХУНГАРДАХ хэтэрхий хунгар болох.

ХУНГАРЛАХ хунгар болох, хунгар тогтох; *нөмөр дагаад цас хунгарласан байв.*

ХУНГАРЛУУЛАХ хунгарлахын үйлдүүлэх хэв.

ХУНДАГА (Н) 1. бяцхан аяга; *архины хундага; хундага барих; хундага өргөх; хундага тулгах;* 2. хүндэтгэвэл зохих хүний буюу хүүхдийн аяга.

ХУНДАГАЛАХ хундаганд юм агуулах, хийх; *архи хундагалах.*

ХУНДАГАЛУУЛАХ хундагалахын үйлдүүлэх хэв; *архи хундагалуулах.*

ХУНДАН 1. хонины нэгэн зүйл зүсэм бөгөөд нүүр толгой ба биед өөр өнгө холилдоогүй цул цагаан зүсэм; *хундан цагаан хонь;* 2. ш и л ж с э н өөр өнгөтэй холиогүй цулгуй; *хундан шар; хундан улаан өнгөөр будах.*

ХУНИА 1. хуниас; 2. ёроол дөрвөлжин бөгөөд амсар дүгрэгхэн хийсэн үйсэн сав,

ХУНИАС эд юманд тусгайлан гаргасан буюу өөрөө бүтсэн, бий болсон атираа; *хувцасны хуниас; хавтганы хуниас;* **хуниас татах** (хувцас хунарын зэрэг юмыг нугалж атируулан хуниас гаргах, хуниастай болгох).

ХУНИАСЛАХ хуниас гаргах.

ХУНИАСТАЙ хуниас бүхий; *хуниастай хүүдий.*

ХУНИАСТАХ юманд хуниас гарах, хуниастай болох; *дээл хуниастах.*

ХУНИРАА 1. тогтсон хуниас; *дээлийн хунираа;* 2. урсгалдаа буюу салхины хүчинд гарсан усны ар; *усны хунираа.*

ХУНИРААТАЛ хунираатах үйлийн нэр.

ХУНИРААТАХ хунираа гарах, хунираатай болох.

ХУНИРААТУУЛАХ хунираатахын үйлдүүлэх хэв, хунираатай болгох.

ХУНИРАХ 1. хунираа гарах; 2. уудам юмны хураамжлагдан багадах, бага болох.

ХУНИРУУЛАХ хунирахын үйлдүүлэх хэв.

ХУНИУЛАХ хунихын үйлдүүлэх хэв.

ХУНИУР юмыг хуних хэрэгсэл; *хүүдийний хуниур; хөөрөгний хуниур.*

ХУНИХ 1. юманд хуниас гаргах буюу хуниасны оосрыг чангаруулан эвхэх; 2. уудам юмыг чухал болгон хумих.

ХУНЛИН у р г а м а л 30—40 сантиметр өндөр ургадаг олон наст ургамал, хурц шар цэцэгтэй, улбар шар өнгөтэй өтгөн шүүс гарна, мал иддэггүй, эмнэлэгт хэрэглэнэ; **хунлин гүн** у р г а м а л (40 орчим сантиметр өндөр, угаасаа салаалан ургадаг иштэй, хөх өнгийн цэцэгтэй, олон наст өвслөг ургамал, эмнэлэгт хэрэглэнэ, бас гүүний хөх ч гэнэ.

ХУНТАЙЗ 1. хааны төрүүлсэн хүү; 2. х у у ч и р с а н феодалын үеийн цол хэргэмийн чимэг.

ХУНХ жавхаа, жавхлан, нүмжиг, үзэмж; *хунхтай морь; хунхтай залуу; хунхтай эд; хунх сайтай; хунх муутай.*

ХУНХГҮЙ хунх, үзэмж муутай, жавхаагүй.

ХУНХТАЙ хунх жавхаа сайтай.

ХУНЧИР у р г а м а л буурцагт ургамлын язгуурт багтдаг олон наст ургамал, үндсий нь эмнэлэгт хэрэглэдэг бөгөөд тэнхээ тамир сайжруулахад сайн гэдэг.

ХУНШ 1. нөхрийн ханилгааны чанар, чансаа; *хунш сайтай нөхөр;* 2. үзэмж, жавхаа; *хунш муутай өнгө.*

ХУНШГҮЙ хунш муутай; *хуншгүй зан биттий гаргаад бай! хуншгүй айл байна.*

ХУНШТАЙ хунш сайтай; *хунштай айлд хуран цуглагчид олон.*

ХУР I хурж хуримтлагдсан юм; **хур баян** (хуучин уламжлалт баян); **хур тарга, хур хүч** (тэжээвэр малын жил өнжсөн тарга); **хур сонгино** (газар өвөлжиж ургасан сонгино); **хур тариа** (а. хуучин гуурснаас ургасан тариа; б. жил удаан хадгалсан тарианы зүйл); **хур дэл** (морь малын мундааны тус хяргаагүй үлдээсэн дэл; б. өнжмөл дэл; *хур дэлтэй, хул морь);* **хур салаа** (мөчрий нь элсэн модноос дахин ургасан нарийн салаа).

ХУР II а м ь т а н модонд оршино, өнгө харавтархан, бие хавтгай, сүүл охор нэгэн зүйл шувуу, хур гургуул ч гэнэ.

ХУР III агаарын тунадас, цас, бороо; **хур бороо, хур тунадас** х о р ш.; **хур орох** (бороо цас орох); **хур буух** (хур орох, тунадас унах); **хурын шүхэр** (борооны халх); **хур ус** (сарны зурхайн ёсны жилийн хорин дөрвөн улирлын нэгний нэр, аргын улирлын хоёрдугаар сарын хорьд орчим тохиолдоно).

ХУРААГДАЛ хураагдсан юм; *хураагдал мал; хураагдлын юмнаас авах.*

ХУРААГДАХ хураахын үйлдэгдэх хэв: 1. бөөгнөрөх, хуралдах; *олон сараар татвар өгөхгүй хураагдсаар байгаад өдий их болсон байна;* 2. амины өмчийг хууль тогтоол ёсоор улс өөрийнхөө мэдэлд шилжүүлэн авах.

ХУРААГУУР аливаа юмыг хураах хэрэгсэл; **дуу хураагуур** (соронзон хальсанд алив дуу чимээг хураах хэрэгсэл); **зай хураагуур** (энерги хурааж, түүнийг зохистой зарцуулах хэрэгсэл).

ХУРААГЧ хураах этгээд: зэвсэг; **хураагч даланлаг** (голын усыг хавчиж, урсах хүчийг түргэн болгосон даланлаг).

ХУРААЛГА хураах үйлийн нэр; *тариа хураалга эхлэх үе ойртож байв.*

ХУРААЛГАХ 1. хураахад хүрүүлэх; 2. хураагдах.

ХУРААЛТ хураалга, хураах үйлийн явц; *намрын тариа хураалтын ажилд явна; будаа хураалтын цаг ойрхон болов.*

ХУРААМЖ 1. хумжаарга, журам, цэгц; *хураамж сайтай айл; номоо хураамжтай тавь!* 2. хураангуйлан хураамжилсан юм; *тоо бодлогын хураамж; сурах бичгийн хураамж дэвтэр.*

ХУРААМЖЛАХ 1. хураах, цэгцлэх, журамтай болгох, эмхтгэх, цомтгох; 2. хураангуйлах; *дэлгэрэнгүй юмыг хураангуйлан хураамжлах.*

ХУРААМЖЛУУЛАХ хураамжлахын үйлдүүлэх хэв.

ХУРААМЖТАЙ эмхтэй, цэгцтэй, хумжаатгатай.

ХУРААНГУЙ дэлгэрэнгүй биш, товч, бага болгосон нь; *утгын хураангуй; тооны хураангуй; хураангуй тоо; хураангуй утга; хураангуй дүн;* **хураангуй хэмжээ** (газрын хол ойрыг зураг зохих харьцаагаар хурааж багтаасныг тодорхойлох шугам масштаб).

ХУРААНГУЙЛАХ юмыг хураангуй болгох, товчлох; *хураангуйлан бичих; хураангуйлж бодох; хураангуйлан тэмдэглэх; бутархай тоог хураангуйлах.*

ХУРААНГУЙЛУУЛАХ хураангуйлахын үйлдүүлэх хэв.

ХУРААХ I 1. хуримтлуулах, нөөцлөх, арвижуулах; *дуслыг хураавал сав дүүрдэг, дуулснаа хураавал мэргэн болдог* с э ц э н; *эд хураахаар, эрдэм хураа* с э ц э н; **юм хураах** (а. эд хөрөнгө хуримтлуулах; б. хогшил хэрэглэлийг эмхтгэн цэгцлэх); **мөнгө хураах** (а. мөнгө төгрөгийг нөөцлөн хуримтлуулах; б. юмны үнэ мөнгийг авах); **хөрөнгө хураах** (эд юмыг хуримтлуулан арвижуулах); **мэдээ хураах** (ямар нэгэн үйл ажлын тухай баримт сэлт цуглуулан авах); **нүгэл хураах** (муу үйл үйлдэх): **буян хураах** (сайн үйл үйлдэх); 2. юмыг ойртуулах, цуглуулах, эмхтгэх, цогцлох, цэгцэтгэх, бэлтгэж авах; **мал хураах** (билчээрлэж байсан малыг хотондоо ойртуулан авчрах); **түлээ хураах** (а. түлээг цэгцлэн жигдэлж тавих; б. түлээ нөөцлөх); **хадлан хураах** (малын нөөц тэжээл болгож өвс хадаж авах); **тариа хураах** (тарьсан тариалангийн үр ургацыг хадаж авах); 3. татварлан авах, албадан авах; **гишүүний татвар хураах** (гишүүний хувьд оногдох татварыг авах); **гааль хураах** (худалдаалах зүйлээс тусгай тогтоосон журмаар татвар авах); **түрээс хураах** (ашиглуулах юмнаас тусгай тогтоосон журмаар татвар авах); **албан татвар хураах** (харьяат ард иргэдээс хууль ёсоор татвар авах); **хөрөнгийг хураах** (бусдын хөрөнгө юмыг хуулиар хүчдэн тулгаж авах); 4. товчлох, цомтгох; *үсэг хураах; утга хураах; тоо хураах;* ☆ **амьсгаа хураах** (үхэх); **дуугаа хураах** (дургүй хүрсэн зүйлд үгээ цөөвчлөх буюу огт дуугарахгүй болох).

ХУРААХ II хүн ардыг өөрийн эрхшээлийн дор дагуулах, баримтлан захирах, нэгтгэх; *өршөөл эрдмээр татан хураах; сүр хүчээр албадан хураах.*

ХУРАГЧ: хурагч бор алаг бялзуухай.

ХУРАЙ уриалах аялгуу, урай.

ХУРАЙЛАХ 1. уриа дуудах; 2. юмыг эргүүлэн сажих.

ХУРАЛ I 1. хүмүүс болон аль нэгэн байгууллагын гишүүд нийлж хэрэг зүйлийг хэлэлцэх цуглаан; **хурал хуй** х о р ш.; *хөдөлмөрчдийн хурал; нэгдэлчдийн хурал; намын үүрийн бүх гишүүдийн хурал; гэгээрлийн хурал;* **Их хурал** (олон нийт, ямар нэгэн байгууллагын дээд эрхийг бариx төлөөлөгчдийн хурал); **бага хурал** (улс, олон нийтийн байгууллагын төлөөлөгчдийн хурал, зөвлөгөөн); **бүгд хурал** (алив хороо, байгууллагын бүх гишүүд оролцох хурал): **хурал нээх** (хурал эхлэснийг мэдэгдэх); **хурал хаах** (хурал төгөссөнийг мэдэгдэх); **хурал хуралдах** (хурал хийх); **хурал завсарлах** (хуралдах явцад түр амрах; *хурал завсарлахаар надтай уулзаарай);* **хурал тарах** (хурал төгсөх); **хурлын дарга** (хурлын хэргийг тэргүүлэн удирдах хүн); **хурлын тэргүүлэгч** (хурлын хэргийг эрхлэн удирдах хүмүүс); **хурлын тогтоол** (хуралаар хэлэлцэн баталж тогтоосон шийдвэр): 2. ш и л ж с э н сонгуулиар байгуулсан зарим албан байгууллага; *Улсын их хуралд ажилтай хүн; Улсын дээд хурал; Улсын доод хурал.*

ХУРАЛ II 1. шашны лам нар олноороо цуглаж шашныхаа зан үйл гүйцэтгэх цуглаан; **хурал ном** х о р ш.; **хурал хуруулах** (лам нараар ном уншуулах); **хурал цэглэх** (хурал завсарлах); 2. ш и л ж с э н лам нар цуглаж шашныхаа зан үйлийг гүйцэтгэх багахан газар, хийд, жас; *хурал дээр очих.*

ХУРАЛДААН ямар нэгэн байгууллагын сонгогдсон буюу томилогдсон гишүүдийн ажил хэргээ зөвлөн хэлэлцэх хурал; *Аюулгүйн зөвлөлийн хуралдаан.*

ХУРАЛДАХ I хуралд оролцох, хурал хийх; *би хуралдаж хуралдаж ирэв; Улсын их хурлын чуулган хуралдаж байхад; Намын их хурал хуралдав.*

ХУРАЛДАХ II 1. хурахын үйлдэлдэх хэв; 2. юм хуримтлан цугларах; *мөнгө хуралдах; хөрөнгө хуралдах; хог хуралдах.*

ХУРАЛДУУЛАХ хуралдахын үйлдүүлэх хэв; *хурал хуралдуулах; хөрөнгө хуралдуулах.*

ХУРАМТ юм хумыг хураан нэмж арвидсаны нь; *хурамт юмтай айл; хурамт эд хөрөнгө сайтайдаа эрдэх; хурамт өвс; хурамт тэжээл; хурамттай байх хэрэгтэй.*

ХУРАМТЛАГДАХ хурамтлахын үйлдэгдэх хэв.

ХУРАМТЛАЛ хурамтлах үйлийн нэр, хурамтлах үйлийн явц.

ХУРАМТЛАХ бага сагаар нэмсээр их болгох; *мөнгө хурамтлах; хоол хурамтлах; ажил хурамтлах; хэрэг хурамтлах.*

ХУРАМТЛУУЛАХ 1. хуримтлахын үйлдүүлэх хэв; 2. хурамтлагдах.

ХУРАНДАА хушууч генерал цолын дараа орох цэргийн даргын дээд цол; **дэд хурандаа** (зэргээрээ хурандаагийн удаа орох цэргийн даргын цол); **хурандаа генерал** (армийн генералын удаа орох цэргийн дээд дарга нарын цол).

ХУРАХ юмс нэг газар бөөгнөрөн цугларах; **хурах цугларах** х о р ш.; *хот суурин газар хүн амьтан олноороо хурах; хотгор газар өвс хог хурах; хоршоо худалдаанд эд бараа хурах.*

ХУРГА (Н) 1. төрөөд нэг жил болоогүй, хонины төл; *хундан цагаан хурга; хурга харшулах; хурганы арьс;* **хурганы уут** (билчээрт төрсөн хургыг агуулах сав); 2. хурганы арьсаар хийсэн эд юм; *хурган малгай; хурган дотор; хурган дээл;* **хурган мэхээр** у р г а м а л (мэхээрийн нэг зүйл, маш жижиг, амт сайн); **хурган мөөг** (талын цагаан мөөгний нэг зүйл, маш жижиг, амт үнэр маш сайхан); **хурган үзэм** (гүнбэрэм буюу зүзэм): **хурган бантан** (нарийлан багсарч хийсэн гурилтай хоол); **хурган чих** у р г а м а л навч бургасны навчтай адил болоод охор, хээр ургадаг нэгэн зүйл ургамал); **хурган шарилж** у р г а м а л (30—50 сантиметр өндөр ургадаг нэг зүйл шарилж, ногоон байхад нь бог мал сайн иднэ, адуу үл иднэ, зарим газар хурган тэрэлж ч гэнэ); **хурган засаа** у р г а м а л (40—50 сантиметр өндөр ургадаг, навч өдлөг бөгөөд бор шаргал өнгөтэй, өндөг хэлбэртэй цоморлогтой, олон наст өвслөг ургамал); **хурган шаваг** у р г а м а л (шавгийн нэгэн зүйл).

ХУРГАЛАХ хонины хурга төрөх; *хонь хургалах.*

ХУРГАЛЖ у р г а м а л үндэснээсээ эхлэн мөчирлөн ургадаг нэг наст ургамал, хур бороотой цагт 30—45 сантиметр, гантай цагт 3—5 сантиметр өндөр ургана, бог мал ба үхрийн сайн чанарын тэжээл болно.

ХУРГАЛУУЛАХ хургалахын үйлдүүлэх хэв.

ХУРГАХ юмны буцаж хоргоцох, эрэгцэх, хулгах; *эргэж хургах; утаа хургах; жавар хургах.*

ХУРД 1. алив үйл хөдөлгөөний түргэний хэм; **хурдтай айл** (уралдааны хурдан морьтой айл); 2. юмны явж өнгөрсөн замыг цагийн нэгжтэй харьцуулсан харьцаа; **дууны хурд** (хатуу бие, шингэн, хийн зүйлд дууны долгионы тархах хурд: хатуу биед 2000—6000 метр) секунд; шингэнд 750—2000 метр) секунд; хийн болон уурын зүйлд 150—1000 метр (секунд); **гэрлийн хурд** (янз бүрийн орчинд цахилгаан соронзон долгионы тархах хурд).

ХУРДАВЧЛАЛ хурдавчлах үйлийн нэр.

ХУРДАВЧЛАХ яаравчлах, түргэвчлэх; *наад ажлаа хурдавчлах хэрэгтэй!*

ХУРДАВЧЛУУЛАХ хурдавчлахын үйлдүүлэх хэв.

ХУРДАН түргэн; **хурдан түргэн, хурдан шаламгай, хурдан гавшгай** х о р ш.; *хурдан явах; хурдан ярих; хурдан унших; хурдан хийх; хурдан ирээрэй; хурдан зан; хурдан бичээч;* **хурдан морь** (довтлоход түргэн холч нь бусад морьдоос давуу); **хурдан буу** (түргэн сумалдаг буу); **хурдан цагаан** у р г а м а л (нэгэн зүйл цэцэг, өнгө хөх, утас будахад хэрэглэнэ).

ХУРДАС эмийн зарим нэгэн бодис хүний биед орсны дараагаар удаан хугацаагаар хэсэг газар байх буюу үргэлжлүүлэн хэрэглэсэн үүраас хэмжээ ихсэж хуралдах бөөгнөрөл.

ХУРДАСГАХ улмаар хурдан болгох, хурдатгах.

ХУРДАСГУУЛАХ хурдасгахын үйлдүүлэх хэв.

ХУДАСГУУР химийн урвалыг хурдасгах бодис.

ХУРДАТГАХ хурдан болгох, хурдасгах.

ХУРДАТГУУЛАХ хурдатгахын үйлдүүлэх хэв.

ХУРДАЧ хурдан шаламгай, түргэч; *хурдач зантай хүн; онин дээрээ хурдач морь.*

ХУРДДАХ түргэдэх, хэтэрхий хурдан болох.

ХУРДДУУЛАХ хурддахын үйлдүүлэх хэв.

ХУРДЛАХ 1. шамдан түргэлэх, бушуулах; *хурдлаарай! явах цаг болов;* 2. хурд нь нэмэгдэх; *машина засмал замд ормогч хурдлан эхлэв.*

ХУРДЛУУЛАХ хурдлахын үйлдүүлэх хэв, хурдан болгуулах.

ХУРДСАХ улам хурдан болох, хурдан нь нэмэгдэх.

ХУРДТАХ улам хурдан болох, хурдсах.

ХУРДХАН нилээд хурдан, арай хурдан, түргэхэн, бушуухан.

ХУРДШИХ хурдан шинжтэй болох

ХУРЖГАНАХ хуржгар юмны үргэлжлэн хөдлөх.

ХУРЖГАР хуйсгар, өнгө зүс муутай; *хуржгар царайтай; хуржгар өнгөтэй.*

ХУРЖИГНАХ хурчигнах.

ХУРЖИЙЛГАХ хуржийхын үйлдүүлэх хэв, хуржгар болгох.

ХУРЖИЙХ хуржгар болох; *царай нь хуржийх.*

ХУРЖИЛЗАХ хуржгар юмны байн байн хөдлөх.

ХУРИЛ хэрэмний орших үүр газар; *хэрэмний хурил.*

ХУРИМ баярын ёсоор олныг хурааж найр хийх; **хурим найр** х о р ш.; *хурим хийх; хурим идэх; хуримын юм; хуримд оролцох;* **хурим той** (гэрлэхийн хурим); **нэрийн хурим** (нэр өгөхийн найр): **нярайн хурим, хүүхдийн хурим** (үр хүүхэдтэй болсны хурим); **гэрийн хурим** (шинэ гэр барьсны хурим); **гэрлэхийн хурим** (эр эм бололцохын хурим); **үхдэлийн хурим, нөгцөний хурим** (нас барагсдыг оршуулсны дараахь хурим).

ХУРИМЛАХ 1. хурим үйлдэх; 2. ш и л ж с э н хурааж авцгаах; *тэднийд байсан савтай айргий нь бид нар сайхан хуримлав.*

ХУРИМЛИГ: хуримлиг цэцэг у р г а м а л хайдан цэцгийн адил бөгөөд иш нарийн, навч ногоон, хүйс няг, улбалзам өнгөтэй нэгэн зүйл цэцэг.

ХУРИМЛУУЛАХ 1. хуримлахын үйлдүүлэх хэв; 2. хуримлагдах.

ХУРИМТЛАГДАХ хуримтлагдахын үйлдэгдэх хэв; *хөрөнгө хуримтлагдах; хуримтлагдсан хог новш.*

ХУРИМТЛАЛ хуримтлах үйлийн нэр, хуримталсан хэмжээ.

ХУРИМТЛАМАЛ хуримтлал юм.

ХУРИМТЛАХ хуримт юмтай болох.

ХУРИМТЛУУЛАХ 1. хуримтлахын үйлдүүлэх хэв; 2. хуримтлагдах.

ХУРИН: хурин шарилж у р г а м а л саргай цэцгийн язгуурын нэг зүйл ургамал.

ХУРЛАХ өвс ургамал ба малын хүч тарга жил өнжиж нэмэн нэмсээр үлэмж болох; *өвс ногоо хуралж байна; манай адуу ойрын жил хуралж байгаа юм.*

ХУРЛУУЛАХ 1. хурлахын үйлдүүлэх хэв; 2. хурлагдах.

ХУРАМ у р г а м а л халуун газар ургадаг нэг зүйл мод, үрийг түүхийгээр буюу хатааж идэж болно.

ХУРМАСТ ш а ш и н гучин гурван тэнгэр нарын эрхэм нэгэн тэнгэрийн нэр; *хан хурмаст; хурмаст тэнгэр.*

ХУРТАЙ I бороо хур элбэгтэй; *энэ жил тун хуртай байна шүү.*

ХУРТАЙ II 1. хурсан, хураасан юм ихтэй; *хуртай баян; хуртай айл;* 2. ш и л ж с э н хур тарга бүхий; **хуртай тарган** (малын жил жилд нэмж таргалсан тарга).

ХУРУУ (Н) I 1. хүн амьтны гар хөлийн сарвуунууд; *хүний хуруу; гарын хуруу; хөлийн хуруу; эрхий хуруу; заах хуруу; дунд хуруу; ядам хуруу; шигчий хуруу; гарын арван хуруу нь гажаагүй шулуун, гартаа хийсэн бөгж нь хольцоогүй шижир дээ* (ардын дуу); **долоовор хуруу** (заах хуруу); **ариун хуруу** (ядам хуруу); **хуруу гаргах** (нэгэн зүйл тоглоом, хоёр хүн нэгэн зэрэг тус тус нэг хуруугаа гаргаж наадах буюу эсхүл хоёр этгээд хуруугаа гаргахын сацуу тоог хэлж наадах хоёр зүйл бий); **хуруу таалцах** (хүүхдийн тоглоом, нэг хүүхэд нь нэг гарынхаа дунд хурууг нууж, нөгөө нэг гарынхаа нэг хурууг нэмж атгаад, нөгөө хүүхдээр дунд хуруугаа олуулж наадах); **хуруу барих** (а. бусдад үл мэдэгдэх гэсэн тоотой юмыг гар барьж харилцан мэдэлцэх; б. хуруу гаргахад нэг нь сүүлдэсхийж

нөгөө этгээдийн гаргах хурууг харах гэсэн байдал гаргах); **хуруу тоолох** (хуруунд нэр өгч, нэрлэн тоолох тоглоом); **хурууны өндөг** (хумсны өмнөх, хурууны үзүүр); **хуруугаар жимэлцэх** (хуалах); **хуруу барих гээд бугуй барих** (завшсан дээрээ бас завшаан эрж явах, ахиж нэтрэх, даврах); **урт хуруутай** (хулгайч; *урт хуруутай хүүхэд);* **хуруу хумсаа нуух** (аж-лаас зайлсхийж биеэ атарлах); **ганц хуруу** (хуруунд тохиолдох нэгэн зүйл өвчин); 2. хуруугаар багцаалсан хэм; *хоёр хуруу зайтай; урт нь дөрвөн хуруу; өргөн нь хоёр хуруу; хуруу зузаан банз; хуруу дарам газар өвдөж байна;* 3. юманд хийсэн хуруу мэт юм; *бээлийний хуруу; таван хуруутай бээлий; нэг хуруутай бээлий;* **тоононы хуруу** (сархинаган тооны уньтай холбох чигжээс мод); **өвчүүний хуруу** (өвчүүний хоёр хажуугийн хавьсанд нийлэлдэх бяцхан ясууд); **хуруун шил** (лабораторийн туршлагад хэрэглэдэг, нэг үзүүрий нь битүү хийсэн нимгэн гуурс шил).

ХУРУУ II нүдний цөцгийд ургаж тогтсон мах мэт зүйл; *нүдэндээ хуруутай;* ☆ **хуруут бүргэд** амьтан (олон зүйлийн бүргэдийн доторхи хамгийн сайхны нь, урт нь 68—72 сантиметр байна, цээжин бие ба хөл цасан цагаан, хүзүүний доод тал хөхөвтөр хар, бусад бие улаан, нүд тойрсон цагариг ба савар цайвар шар, хушуу ган төмрийн өнгөтэй, хошоочноор явна, дуу маш хол сонсдоно, загас амьтны сэгийг иднэ); **хуруут хэрээ** амьтан (омруудаа хар бидэртэй, улаан өнгөтэй хэрээ).

ХУРУУВЧ (ИН) 1. юм оёход зүүг жийрэглэн түлхэх хэрэглэл; *булигаар хуруувч; төмөр хуруувч;* 2. шилжсэн маш жижиг; *хуруувчин чинээн хундагатай юм;* **хуруувчин цэцэг** ургамал (нэгэн төрлийн өвслөг ургамал, навчийг зүрхний өвчин эмчлэхэд хэрэглэнэ).

ХУРУУВЧЛАХ хуруундаа хуруувч зүүж хэрэглэх.

ХУРУУД хэсэглэн тавьсан том ааруул; **ааруул хуруул** хорш.,

ХУРУУДАХ 1. хуруунаас барих; 2. хуруу гаргаж наадах.

ХУРУУЛАХ хурахын үйлдүүлэх хэв, хурж цугларахад хүрүүлэх.

ХУРУУТАХ ганц хуруугаар өвчлөх; *ганц хуруутах.*

ХУРХАГ 1. дутуу, турхан, **мөхөс** ядуу; *хурхаг дутуу; хурхаг турхан; мөхөс хурхаг; хурхаг ядуу;* 2. арвич, харамч; **арвич хурхаг, харамч хурхаг** хорш.

ХУРХАГЛАХ юмыг их л хэмнэн арайхан зөвхөн хэрэглэх, харамлах.

ХУРХИРАХ унтахад хоолой хамар хоржигнон дуугарах.

ХУРХИРУУЛАХ хурхирахын үйлдүүлэх хэв.

ХУРЦ 1. мохоо биш, иртэй, үзүүртэй; *хутга хэдий хурц боловч ишиндээ тусгүй* зүйр; **хурц мэс** (ир сайтай мэс); **хурц үзүүр** (шовх үзүүр); **хурц ир** (даалт сайтай ир); 2. алив юмны ид чадал илүү, давуу; **хурц нар** (маш тунгалаг, шарам халуун нар); **хурц гэрэл** (маш гялбам гэрэл); **хурц өнгө** (маш тодорхой өнгө; *хурц улаан; хурц шар);* **хурц хараа** (ажигч хараа); **хурц нүд** (а. хараа сайтай нүд; б. ширүүн хөдөлгөөнтэй харцтай); **хурц халуун** (маш халуун): **хурц ухаан** (ухах хурдан, сэцэн ухаан); **хурц хүн** (сэцэн хэлэмгий хүн); **хурц зан** (түргэн догшин зан); **хурц хэл** (өгүүлэхдээ уран чадамгай хэл); **хурц үг** (онож хэлсэн сэцэн мэргэн үг); **хурц явдалтай морь, хурц морь** (морь малын хурдан ирмүүн явдал); **хурц идээ** (нүмжиг ихтэй шандуурам идээний зүйл); **хурц шөл** (ааг амт ихтэй шөл): **хурц өөх** (маш тослог өөх); **хурц амт** (маш нялуун амт); **хурц үнэр** (ааг ихтэй үнэр); **хурц өвчин** (сочмог хүнд өвчин); ☆ **хурц улаан цэцэг** ургамал (салаа тармаг, цэцэг нягт, хоёр буюу гурван сард цэцэглэнэ, урьдаар навч ургаж хойно цэцэглэх нь бий бас цэцэглэсэн хойно навч ургах нь ч бий, өнгө цусны адил улаан, уулын завд ургадаг нэгэн зүйл цэцэг); **хурц шар цэцэг** ургамал (хурц улаан цэцгийн адил болоод өнгө шар, үнэр муухай, хортой нэгэн зүйл цэцэг).

ХУРЦАВТАР баахан хурц, арай хурц.

ХУРЦАДМАЛ хурцдах үйлийн нэр; *олон улсын харилцаа хурцадмал хэвээр байгаа энэ үед.*

ХУРЦАСГАХ улам хурц болгох.

ХУРЦАТГАХ хурцлах, хурцасгах.

ХУРЦДАХ 1. хэтэрхий хурц болох; 2. аливаа юмны ид чадал хэтэрхий хурц болох; *хоол хурцдах; гэрэл хурцдах.*

ХУРЦДУУЛАХ хурцдахын үйлдүүлэх хэв.

ХУРЦЛАХ хурц болгох.

ХУРЦЛУУЛАХ хурцлахын үйлдүүлэх хэв.

ХУРЦСАХ улам хурц болох.

ХУРЦТАХ хурц болох, хурцсах.

ХУРЦХАН баахан хурц, арай хурц.

ХУРЧИГНАХ хурчиг хурчиг чимээ гарах; *ус хурчигнан урсах; гэдэс хурчигнан дуугарах.*

ХУРЧИГНУУЛАХ хурчигнахын үйлдүүлэх хэв.

ХУРШААЛГАХ хуршаахад хүргүүлэх.

ХУРШААХ хурших I-ийн үйлдүүлэх хэв, хуршихад хүргүүлэх.

ХУРШИХ I идээ идэшний зүйл удаж хуучран гажуу амттай болох; *мах хурших; тос хурших; өөх хурших.*

ХУРШИХ II идсэн уусан юмны давхардаж шингэц муутай болох; *хоол хурших; баас хурших.*

ХУРШИХ III хур бороoны элбэгших, хур бороо ормоор шинж төлөвтэй болох.

ХУРШИХ IV хуримталсан юмтай болох.

ХУРШМАЛ хуршсан юм; *хуршмал тос; хуршмал өөх; хуршмал амт.*

ХУРШУУЛАХ хуршихын үйлдүүлэх хэв.

ХУРЬЦАЛ хурьцах үйлийн нэр, шунал, дурлал; *хурьцал төрөх; хурьцал үйлдэх.*

ХУРЬЦАЛДАХ хурьцахын үйлдэлдэх хэв, харилцан хурьцах.

ХУРЬЦАЛДУУЛАХ хурьцалдахын үйлдүүлэх хэв.

ХУРЬЦАНГУЙ шунах, үжидлэх сэтгэл, *хурьцангуй сэтгэлийг тэвчих нь чухал.*

ХУРЬЦАХ юманд дурлан шунахайрах, тачаах; *эд юманд хурьцах; өнгөнд хурьцах.*

ХУРЬЦУУЛАХ хурьцахын үйлдүүлэх хэв.

ХУС (АН) I у р г а м а л өнгө цагаан, навч бяцхан, мах нарийн болоод чийрэг нэг зүйл мод, үүний дурсыг үйс гэнэ; *хусан тооно; хусан уурга.*

ХУС II идээ жимс хийх нэгэн зүйл сав, багвар ч гэдэг.

ХУС III: **хус чулуу** нэгэн зүйл чулууны нэр, чанар маш зөөлөн.

ХУСАМ 1. сүү зэрэг идээний зүйлийг буцалгах чанахад түлэгдэж тогоонд тогтсон хаг; *хар хусам; бор хусам;* 2. үлдэгдэл юм; **хусамтай айл** (юмтай айл, хур юм сайтай).

ХУСАМТАХ 1. хусам тогтох; 2. юу ч үгүй мэт байдалтай болох; *тэднийх ч бүр хусамтаж орхижээ.*

ХУСАМТУУЛАХ хусамтахын үйлдүүлэх хэв.

ХУСАХ 1. юмыг харах, малтах; *усий нь хусах; хальсы нь хусах; хүрзээр хусах; хусмы нь хусах;* 2. сав суулгад хийсэн үр тариа зэрэг үүрмэг юмыг яндаж тэгшлэх; *шанаганд хийсэн будааг хусах;* 3. хонжин мөлжих; *би ганс ны наймаа хийж түүнийг сайн хусав шүү.*

ХУСЛИГ у р г а м а л иш бүдүүн болоод том, навч хар хусны адил боловч баахан бага нэг зүйл мод.

ХУСЛУУР хус модны дурс, үйс ч гэдэг.

ХУСРААХ хусрахад хүргүүлэх.

ХУСРАН малын хусарсны нь; *хусран үнээ, хусран гүү.*

ХУСРАХ I охин малын сувайрсан боловч, ноднин жилийнхээ төлийг хөхүүлэн саалгаж байх; *үнээ хусрах; гүү хусрах.*

ХУСРАХ II ядуурч хоосрох; *тэднийх ч хусарч яваа айл билээ.*

ХУСУУЛАХ 1. хусахын үйлдүүлэх хэв; 2. хусагдах.

ХУСУУР 1. харах, хусах хэрэгсэл; *тогооны хусуур;* 2. морь малын хөлсийг арилгах эвэр буюу хулс зэргээр хийсэн хутга мэт юм; *морины хусуур;* 3. сав суулганд хийсэн үр тариа зэрэг үүрмэг юмыг яндахад хэрэглэх нарийн хавтгай мод; *будаа тарианы хусуур;* 4. мөлжимтгий **зантай**; *хусуур хүнтэй наймаа бүү хий.*

ХУСУУРДАХ 1. хусуураар хусах; *будаа хусуурдаж яндах;* 2. хэтэрхий хонжиж мөлжих.

ХУСУУРЧИН 1. үр тариа зэрэг үүрмэг зүйлийг саваар хэмжиж худалдаа хийдэг хүмүүс; 2. дамын пазчин.

ХУТАГ 1. горилсон хүсэл; *өршөөл хамгаалалдаа авах хүтэйг гуйна;* 2. хувь зохиол; *насан хутаг урт; хутаг сайтай;* **хутаг олох** (а. хувь зохиол олох; б. олиг өвчин олох).

ХУТАГТ шашны ёсны сайны хүтаг олсон хувилгаадад олгох цол; **хутагт хувилгаад** х о р ш..

ХУТГА (Н) нэгэн этгээдэд иртэй, бариул бүхий огтлох зэвсэг; **хутга шөвөг, хутга жад, хутга мэс, хутга сэлэм** х о р ш.: **хутган жад** (хутга хэлбэртэй жад); **хутганы иш** (хутганы бариул); **хутганы ишийн толт** (хутганы ишийн тав); **хутганы ир** (хутганы огтлох этгээд); **хутганы ховил** (хутганы хажуугийн суваг); **хутганы хуй** (хутганы гэр); **хутганы мөр** (хутганы ар ирийн эсрэг этгээд); **хутганы үзүүр** (а. хутганы шовх этгээд: б. хүнээс хутга хэрэглэхээр авч, түүнд хутгын хамтаар эргүүлж өгөх хувь); **хутганы ир дээр** (үйл явдлын хааш болох магадгүй, нааш цааш болохыг болзохуяа бэрх байгаа үе); ☆ **хутган сод** (шувууны хамгийн урт өд).

ХУТГАЛАХ I байн байн хөршин хутгах.

ХУТГАЛАХ II хутга барьж чичих.

ХУТГАЛДАХ хутгахын үйлдэлдэх хэв; **холилдох хутгалдах** х о р ш..

ХУТГАЛДУУЛАХ хутгалдахын үйлдүүлэх хэв.

ХУТГАЛУУЛАХ 1. хутгалахын үйлдүүлэх хэв; 2. хутгалагдах.

ХУТГАЛЦАХ хутгахын үйлдэлцэх хэв.

ХУТГАЛЦУУЛАХ хутгалцахын үйлдүүлэх хэв.

ХУТГАМЦАГ хутгамш.

ХУТГАМШ өрөм тосонд ээзгий ааруул мэтийг хольж хутган умшилсан нэгэн зүйл идээ.

ХУТГАМШЛАХ хутгаж умш хийх, хутгамш хийх; *өрөм ээзгий хутгамшлах.*

ХУТГАХ 1. хооронд нь хольж нийлүүлэх, хоршиж нийцүүлэх; **холих хутгах** х о р ш.; *тараг хутгах; хоол хутгах;* 2. утгах; *шанагаар хутгаад ав! халбагаар хутгаад ид!* 3. ш и л ж с э н сүлж хольж үймүүлэх; *үймүүлж хутгах; ховолж хутгах;* **бөөлжис хутгах** (бөөлжмөөр болох).

ХУТГУУЛАХ 1. хутгахын үйлдүүлэх хэв; 2. хутгагдах.

ХУТГУУР 1. юмыг хутгах хэрэглэл; *айргийн хутгуур; тосны хутгуур;* 2. хов зөөдөг; *хутгуур хүн;* **төрийн хутгуур, төмрийн хуурай** (төрийн явдлыг хутган үймүүлж хор хүргэгч гэсэн санаа).

ХУУ I шингэн юм агуулах данх сав, төмөрлөгөөр хийнэ, хэлбэр *олон янз;* **хуу домбо** х о р ш.; **саа хуу** (галд гударч шингэн юм халаахад зориулсан домбо мэт хэлбэртэй, хараагүй, гозгор төмөрлөг сав).

ХУУ II нэгмөсөн, дуустал, бүгдээр нь гэх санаа илэрхийлэхэд хэрэглэх аялга; *хуу шатах; хуу хураах; хуу барах; хуу явцгаа!*

ХУУ III хүч нэмэгдүүлэх үг; **хуу татах** (юмыг татаж хуулах; *өнгий нь хуу татах; арьсы нь хуу татах).*

ХУУВИЛДАХ хүмүүсийн хоорондоо нууцаар үгсэн эвлэлдэх; *нам нийлж сэм хуувилдах.*

ХУУВЬ хуралдаж зөвшин хэлэлцэх зөвлөл; **хуувь нийлэх** (хэрэг зүйлийг хэлэлцэхээр хуралдах): **хуувийн сайд** (зөвлөх сайд буюу яамгүй сайд).

ХУУГИА хөнгөн болгоомжгүй авир зантай; **хөнгөн хуугиа** х о р ш.; *хуугиа хүн; хуугиа морь.*

ХУУГИАДАХ хэтэрхий хуугиа болох.

ХУУГИАРАХ хуугиа болох; *дэмий хуугиарах хэрэг алга, ажлаа хий!*

ХУУГИАТАХ хуугиа зан байдал гаргах; *чи битгий хуугиатаад бай!*

ХУУГИНАХ I санаснаа далдлахгүй гаргаж хэлэлцэх; *хуугинан хэлэлцэх дуртай өвгөн.*

ХУУГИНАХ II урсгал усны шуугиж чимээлэн урсах; *хуугинан урсах чимээг чагнасаар унтчижээ.*

ХУУГИНУУЛАХ хуугинахын үйлдүүлэх хэв.

ХУУГИХ I хөнгөн болгоомжгүй авирлах, хуугиа зан байдал гаргах.

ХУУГИХ II их ус буюу салхины шуугих дүнгэнэх чимээ гарах; *хуугитал урсах; салхи хуугиж байна.*

ХУГУУНИХ шувууны жигүүр хавчин довтлох, шүнгах; *харцага хугууних; бүргэд хугуунних.*

ХУУДАМ хөнгөн, мөчид, болгоомжгүй, хуумгай; *хөнгөн хуудам зан гаргах.*

ХУУДАМДАХ хуудам нь дэндэх.
ХУУДАМЛАХ хуудам зан ааш гаргах.
ХУУДАМНАХ хуудам байдал гаргах.
ХУУДАМТАХ хуудам зан гаргах.
ХУУДАН: **хуудан шувуу** а м ь т а н тахианы адил нэгэн зүйл шувуу, өдөр шөнөгүй дуугардаг бөгөөд өвлийн дунд сар болоход дуугарахгүй болно.

ХУУДАС (АН) 1. ном бичиг дэвтрийн цаас, нэгэн ширхэг сул цаас; *нэг хуудас цаас; арван хоёр хуудастай дэвтэр; аравдугаар хуудас; хуудас хуудсаар нь эргүүлэх;* 2. бичмэл болон машиндсан зүйлийн хэмжээг тооцох хэвлэлийн нэгж; **зохиогчийн хуудас** (зохиогчийн зохиолыг хэвлэлийн дөчин мянган үсгийн тэмдэгтээр бодсон нэгж); **хэвлэлийн хуудас** (60x84; 60x92; 70x92; 70x108: 84x108 сантиметрийн хэмжээтэй хэвлэлийн цаасны талбайн хэмжээ); 3. зарим нэгэн бичиг буюу захиа баримт; *албан хуудас явуулав; хуудас бичиж үлдээв;* **илтгэх хуудас** (албан хэргийн тухай дээд газарт илтгэх бичиг); 4. дээл хувцасны дотроос салгаж авсан өнгө хуулга; *хуучин дээлийн хуудсаар хийсэн юм;* ☆ **далны хуудас** (амьтны далны толин дээрх мах; *далны хуудсыг далан хүн хувааж идэх* з ү й р); **хуудас мах** (мал гөрөөсний далны ховилын дотоод мах); **хуудас алт** (юм будах ширдэхэд зориулж хийсэн нимгэн алт: нисэх алт, цаасан алт ч гэдэг); **хуудас төмөр** (нимгэн гөлмөн төмөр); **уулын хуудас** (уул нурууны доош буусан хамрын хажуу дахь тэлүүхэн хотгор нугачаа).

ХУУДАСЛАХ хуудас болгох.
ХУУДАСРАХ хуудас болох.
ХУУДУУ базаахгүй зан байдал; *хуудуу гаргах.*
ХУУДУУГҮЙ төлөв томоотой, гүндүүгүй сайн; *тэр гуай ч ёстой хуудуугүй хүний нэг мөн.*
ХУУДУУТАЙ төлөв зэхий байдалтай; *хуучин хүн хуудуутай.*
ХУУЗ хүний шанаа эрүүнд ургасан битүү үс; *хууз сахалтай хүн.*
ХУУЗРАХ хуузтай болох.
ХУУЗШИХ хууз ургах шинж орох.
ХУУЛАХ I хуурахад хүрүүлэх; *хучлага хуулах; арьс хуулах; хальсыг нь хуулах; дээлийн өнгө хуулах.*

ХУУЛАХ II 1. юмыг буулгаж бичих; зурах; *бичиг хуулах; зураг хуулах; дэвтэр дээр хуулах;* 2. дууриалгаж хийх.
ХУУЛБАР хуулж буулгасан юм; *хуулбар бичиг; хуулбар зураг; бичгийн хуулбар; хуулбар үнэн.*
ХУУЛБАРДАХ хуулбарыг хувилж авах.
ХУУЛБАРЛАХ хуулж буулгах.
ХУУЛГАХ хуулуулах.
ХУУЛИГҮЙ дүрэм цааз, хорио цээр тогтоогдоогүй; *хуулигүй юм хийх.*
ХУУЛИЛАХ 1. хууль болгож тогтоох; 2. хууль ёсоор шийтгэх.
ХУУЛИЛУУЛАХ 1. хуулилахын үйлдүүлэх хэв; 2. хуулилагдах.
ХУУЛИРХАХ хууль дүрэм мэддэг гэж гайхуулах, хуулиар далайлган сүрдүүлэх.
ХУУЛУУЛАХ 1. хуулахын үйлдүүлэх хэв; 2. хуулагдах.

ХУУЛЬ 1. тогтмол зүйн дотор илэрч гарах жинхэнэ үнэн байдлын аливаа үзэгдлүүдийн хоорондын холбоо ба харьцах зүй тогтоол; *байгалийн хууль; нийгмийн хөгжлийн хууль; сэтгэхүйн хууль;* 2. засгийн дээд эрхийг барих газраас заавал дагаж шийтгүүлэхээр баталсан тогтоол; **хууль цааз, хууль дүрэм** х о р ш.; **үндсэн хууль** (улсын тулгуур хууль); **эрүүгийн хууль** (шийтгэвэл зохих гэмт хэргүүдийг тодорхойлон, хэрэгтэн этгээдүүдэд оноох ял шийтгэл заасан хууль); **иргэний хууль** (ард иргэдийн хоорондын эрх үүрэг, харьцаа, хариуцлага учир холбогдлыг тодорхойлсон дагаж шийтгүүлэх хууль); **хөдөлмөрийн хууль** (ажилчин албан хаагчдын хөдөлмөрлөх эрх үүргийн тухай хууль): **хуулийн нас** (хуулийн эрх эдлэх, эдлүүлэхээр зааж тогтоосон нас); **хуулийн төлөвлөгөө** (аливаа хуулийг зохиож боловсруулсан төсөл); **хууль гаргах** (аливаа хуулийг тогтоон тунхаглах); **хууль сахих** (хууль ёсыг мөрдөж дагах); **хууль сахигч** (хууль ёс биелүүлж бий эсэхийг хянагч, прокурор); **хууль хамгаалагч** (прокурор); **хуулийн байгууллага** (шүүхийн байгууллага); **хуулийн хариуцлага** (хуулийн өмнө хүлээвэл зохих хариуцлага); **хууль бус** (хууль зөрчсөн, хуулиас ангид; *хууль бус хэрэг өдүүлэх);* **хууль цаазны ухаан** (шүүх цаазны тухай ухаан); **хууль цаазын сургууль** (хууль цаазын ухаан судлах сургууль); **хууль цаазач** (хууль цаазын мэргэжилтэн); **хуулийн суртал нэвтрүүлэг** (гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргий-

лэх тухай олон түмэнд таниулах суртал нэвтрүүлэг); 3. нийтээр заавал дагаж журамлах ёстой гэж үзсэн зүйл; **хэв хууль** х о р ш.; *улсын төлөвлөгөө бол хууль.*

ХУУЛЬДАХ хууль дүрэм дурдах; **хуульдах дүрэмдэх** х о р ш.; *чи бичгий хуульдаад байгаарай.*

ХУУЛЬСАХ хуульдах, хууль дүрэм дурсах; **хуульсах дүрэмсэх** х о р ш..

ХУУЛЬТАЙ хууль бүхий; *хуультай хэрэг; хуультай зүйлийг бүү зөрч!*

ХУУЛЬЧ хуулийн мэрэгжилтэн.

ХУУЛЬЧЛАХ хуулийг ёсчлон биелүүлэх, хууль болгон дагуулах.

ХУУЛЬЧЛУУЛАХ хуульчлахын үйлдүүлэх хэв.

ХУУЛЬШИХ хуулийн шинж чанартай болох.

ХУУМГАЙ хянамгайгүй, омтгой, мөчид, хөнгөн, цалгай; *хөнгөн хуумгай, мөчид хуумгай* х о р ш..

ХУУМГАЙДАХ хэтэрхий хуумгай болох.

ХУУМГАЙЛАХ хуумгай зан гаргах ба юмыг омтгойлон үзэх.

ХУУМГАЙРАХ хуумгай байдал гаргах.

ХУУМГАЙТАХ хуумгай зан гаргах.

ХУУР хөгжмийн зэвсэг; *хуур дарах;* **морин хуур** (хуурын чихний дээд талд морины толгойг сийлэн гаргаж, чавхдас, нумны хөвчийг морины сүүлний хялгасаар хийсэн монгол үндэстний нэг зүйл хөгжмийн зэвсэг); **баян хуур** (а. нэгэн зүйл авсаар бадралт баг бишгүүр; б. нэг зүйл даралтат хөгжмийн зэвсэг); **төгөлдөр хуур** (том хайрцагт олон чавхдас татсан бөгөөд даралт дээр нь дарвал даралтын үзүүрийн жижиг алх мэт юм чавхдасыг оноож дуу гаргах нэг зүйл хөгжмийн зэвсэг): **аман хуур** (а. олон жижиг нүхэнд төмөрлөгөөр хэл тааруулан хадсан бөгөөд нүхээр нь үлээвэл төмөрлөг хэл нь доргиж дуугарах нэгэн зүйл хуур; б. хэл хуур); **хэл хуур** (хулсаар хийсэн жижиг хуур).

ХУУРАЙ I төмөрлөгийн зүйлийг үрж хавиран элээх багаж; *хөрөөний хуурай; бөөрөнхий хуурай; дөрвөлжин хуурай; хавтгай хуурай.*

ХУУРАЙ II нойтон гэдгийн эсрэг утга, нойтон чийггүй; *хуурай газар; хуурай мод; хуурай даавуу; хуурай банз, хуурай идэш; хуурай болтол арчих; хуучин хүн хуудуутай, хуурай будаа чулуутай* с э ц э н; **хуурай жимс** (хатаасан жимс); **хуурай сүү** (нунтаглаж хатаасан сүү); **хуурай өндөг** (нунтаглаж хатаасан өндөг); **хуурай зам** (усгүй газраар явах зам); **хуурай салхи** (хур бороогүй үргэлжлэн салхилах халуун салхи); ☆ **хуурай хүү** (өөрөө хүсч ирээд үр нь болсон хүү): **ам хуурай суухгүй** (а. үргэлж идэж байдаг; б. дандаа ярьж байдаг); **хуурай хоолой** (амьсгал авах мөгөөрсөн хоолой); **хуурай үе** (ясны хөдөлгөөнгүй үе).

ХУУРАЙДАХ I хуурайгаар үрэх.

ХУУРАЙДАХ II хэтэрхий хуурай болох.

ХУУРАЙДУУЛАХ хуурайдахын үйлдүүлэх хэв.

ХУУРАЙЛАХ 1. нойтон чийгтэй юмыг хатааж хуурай болгох; *нар салхинд хуурайлах;* 2. норсон нойтон зүйлийг хуурай зүйлээр солих, халах; *хүүхэд хуурайлах; өвчтөн хуурайлах;* 3. ш и л ж с э н юмыг дуустал цөлмөж үгүй болгох; *эд хөрөнгийг барж хуурайлах; идэх уух зүйлийг дуусгаж хуурайлах.*

ХУУРАЙЛУУЛАХ 1. хуурайлахын үйлдүүлэх хэв; 2. хуурайлагдах.

ХУУРАЙСАХ хуурай байдалтай болох; *хоолой хуурайсах, ам хуурайсах, дотор хуурайсах;* **хуурайсч өвдөх** (жирэмсэн хүн төрөхдөө ус нь урьтаж гарчихаад, дараа нь их өвдөх).

ХУУРАЙШИХ хуурай шинжтэй болох.

ХУУРАЛХИЙЛАХ худал хуурмагаар дэмий хэлэлцэн явах.

ХУУРАМЧ үнэн бодьтой биш; *хуурамч алт; хуурамч зан; хуурамч хүн; хуурамч хэрэг.*

ХУУРАМЧДАХ хэтэрхий хуурамч болох.

ХУУРАМЧЛАХ хуурамч зан байдал гаргах, хуурч мэхлэх.

ХУУРАМЧХАН баахан хуурамч, нилээд хуурамч; *хуурамчхан амьтан.*

ХУУРАХ I арьс хальс зэргийн юм өөрөө өвчрөн салах; *модны холтос хуурах; гарын арьс хуурах; наасан цаас нь хуурчээ.*

ХУУРАХ II оргүй юмыг зохиож хэлэлцэх; **хуурах мэхлэх, хуурах залилах** х о р ш.; *хуурсаар хуурсаар худалч болох.*

ХУУРАХ III хоол идээний зүйлийг халуунд хайрч болгох; *мах хуурах; ногоо хуурах; тариа хуурах.*

ХУУРГА ногоо, мах зэрэг идэшний зүйлийг хөшиглөн жижиглэж, тостой хутган хайрч болгосон идээ; *махан хуурга; мөөгтэй хуурга; будаатай хуурга; төмстэй хуурга; пүнтүүзтэй хуурга.*

ХУУРГАЛАХ хуурга хийх; *ногоо хуургалах.*

ХУУРДАХ хуур хөгжмөөр хөгжимдөх.

ХУУРДУУЛАХ хуурдахын үйлдүүлэх хэв.

ХУУРМАГ үнэн биш, худал; **худал хуурмаг** х о р ш.; *хуурмаг зан гаргах; хуурмаг сүр үзүүлэх.*

ХУУРМАГДАХ хэтэрхий хуурмаг болох.

ХУУРМАГЛАХ I худал үгээр хуурч залилах, мэхлэх; *хуурмаглан хэлэлцэх; хуурмаглан айлгах.*

ХУУРМАГЛАХ II үр будааны зүйлийг бяцхан хуурч болгох.

ХУУРМАГЛУУЛАХ 1. хуурмаглахын үйлдүүлэх хэв; 2. хуурмаглагдах.

ХУУРС бөөсний өндөг.

ХУУРСЛАХ хуурсы нь арилгах.

ХУУРСТАХ хуурстай болох; *гээгэ хуурстах.*

ХУУРСТУУЛАХ хуурстахын үйлдүүлэх хэв.

ХУУРТАХ бусдын хуурмаг үйл явдалд мэхлэгдэх, хуурагдах, залилагдах.

ХУУРЦАГ юм хум агуулах, авдраас бяцхан хайрцаг сав.

ХУУРЦАГЛАХ хуурцагт агуулах.

ХУУРЧ (ИН) хуурдахдаа чадамгай хүн; *морин хуурч; төгөлдөр хуурч.*

ХУУСДАХ хуудамлах, омтгойдох, наагуурдах, мөчиддөх, хуусдуу зан гаргах; *хуусдах бий, мэдээрэй!*

ХУУСДУУ хуудам, омтгой, гэнэн, хийсвэр, хөнгөн; *тун ч хуусдуу хүн; чи өдий нас хүрээд ийм хуусдуу байж, яаж болох билээ.*

ХУУХ эр амьтны бэлэг эрхтэн мөн түүний арьс, хуухнаг.

ХУУХИНАХ хохинох; *хуухинан дуугарах; хуухинан амьсгаадах.*

ХУУХИРАХ адуу, буга зэргийн амьтны юмнаас айн хэлмэж буюу сочиж сэжиглэн хамраа хорд хийлгэн дуугарах; *морь хуухираад байна, юу үзсэн юм бол доо.*

ХУУХИРУУЛАХ хуухирахын үйлдүүлэх хэв.

ХУУХНАГ эр амьтны үр-булчирхайн хүүдий хуух.

ХУУХЬТНАХ хуухинах, шуухинах; *тэнд л хуухьтнаад байна, юу хийж яаж байгааг бүү мэд.*

ХУУЧ (ИН) шинэ гэдгийн эсрэг утга; 1. элэгдэж хуучирсан, муудсан юм; *хуучин гутлаа тахалж өмсөв; хуучин дээл; хуучин мах;* 2. урьд, урьдын; *хуучин байрандаа байгаа; хуучин ажлаа хийсээр л байна; хуучин тайж явсан хүн; гэм биш зан; гэнт биш хуучин* з ү й р; **хуучин удирдлага** (урьд байсан удирдлага): 3. эрт, эртний, өнгөрсөн үеийн **хуучин танил** (эрт урьдын танил); **хуучин нөхөр** (эрт урьдын нөхөр); **хуучин заншил, хуучин зуршил** (эртнээс уламжлагдаж хэвшсэн зан суртахуун); **хууч үг** (эцэг өвгөдөөс уламжлагдаж ирсэн сургаалт үгс); **хуучны судлал** (эртний судлал, археологи); **хуучны дурсгалт зүйл** (эртний дурсгалт зүйлс); **хуучин данс хараа** (өнгөрсөн үеийн бичиг дансны зүйл): **хууч хөөрөх, хууч ярих** (өнгөрсөн үйл явдлын тухай хүүрнэн хэлэлцэх; *хуучаа ярих гээд хулгайгаа ярих);* **хуучин цаг** (үеэ өнгөрүүлсэн цаг); **хуучин хүн** (а. урьд байсан хүн; б. хашир догь болсон хүн); **хуучин бууны хугархай** (а. юм үзэж нүд тайлсан; б. хур юмны үлдэцтэй); 4. архаг; **хууч хөдлөх** (архаг өвчин сэргэж өвчлөх); **хуучин өвчин** (удаж архагшиж тогтсон өвчин); 5. сүүл, шувтрага; **сарын хууч** (сарын сүүлийн арав хоног); **хуучин үдэш** (сарны зурхайн ёсны арван хоёрдугаар сарын гучны үдэш, битүүн ч гэдэг.

ХУУЧВАР хуучивтар.

ХУУЧДАХ хэтэрхий хуучин болох; *наадахь чинь арай л хуучдаад байна даа; чингэвэл энэ бас хуучдах биз ээ.*

ХУУЧДУУЛАХ хуучдахын үйлдүүлэх хэв.

ХУУЧИВТАР бага зэрэг хуучирсны нь; *хуучивтар хүрэн торгон дээл авдраасаа гаргаж өмсөв.*

ХУУЧИД I 1. монголын нэгэн овгийн нэр, өвөр монголд бий; 2. хүний дээд үеийн овгөд; **овгөд хуучид** х о р ш..

ХУУЧИД II жил сарын дундуураас хойших буюу сүүлчийн хувь; *жилийн хуучид; сарын хуучид.*

ХУУЧИР нэгэн зүйл чавхдаст хөгжмийн зэвсэг; *хуучир шанзаар тоглох.*

ХУУЧИРДАХ хуучир хөгжмөөр хөгжимдөх.

ХУУЧИРДУУЛАХ хуучирдахын үйлдүүлэх хэв.

ХУУЧИРЧ хуучир хөгжимд мэрэгжсэн хүн.

ХУУЧИС 1. өвөг дээдэс, овгөд хуучид; *хуучсын яриа;* 2. хуучирсан юмс; *хуучис худалдагч; хуучис худалдах газар.*

ХУУЧИХ 1. байн байн хуулах; *газрын хөрс хуучих; хучлагаа хуучих;* 2. учир нажиргүй ярих; *насжаад хуучих дуртай болсон юм билээ.*

ХУУЧЛАХ хууч хөөрөх, хууч ярих; *хоёр өвгөн хуучилж суна.*

ХУУЧЛУУЛАХ хуучлахын үйлдүүлэх хэв.

ХУУЧРАХ 1. хуучин болох; *дээл хуучрах; хоол хуучрах;* 2. удаж улирах; *цаг уе хуучрах; сар хуучрах; хоног хуучрах.*

ХУУЧРУУЛАХ хуучрахын үйлдүүлэх хэв.

ХУУШАЛН хөхийн шашны лам.

ХУУШУУР мах татаж ногоо давс холин гурилд хучиж, хавтгайлан хайрч болгосон хоол; *хуушуур хайрах.*

ХУХАН архи зэргийн маш хатан хашралтай амт.

ХУХРАХ хухан амттай болох.

ХУХРУУЛАХ хухрахын үйлдүүлэх хэв.

ХУХТАЙ бага хүүхдийн нойр ихтэй.

ХУЦ агтлаагүй эр хонь; **хуц тавих** (эр хурга төлгийг агтлахгүй үлдээж хуц болгох); **хуцаа тавих** (ялгасан хуцыг уг сүрэгт нь буцааж нийлүүлэх); **хуц хорих** (хуцад хөг зүүх); **хуц ялгах** (эм хонийг зохистой цагт төллүүлэхийн тул зуны цагт хуцыг эм хониноос салгаж тусгаар адуулах); **хуцаа нийлүүлэх** (хуцаа тавих); **хуц хөөх** (хуц, эм хонио дагаж хээлтүүлэх); **хуц дагах** (хуц, эм хонио бараадан явах ба хөөх); **хуцын хөг** (хуцын хонио цаг бусаар хөөхөөс болгоомжлон засаагий нь халхлан уях хэрэгсэл); **хуц гүйх** (хуц хөөх); **хуцын хуух, хуцын хуухнаг** (цэцэг нь задраагүй байхдаа бундуу нь зууван бөөрөнхий хэлбэртэй байдаг ургамлуудын ерөнхий нэр); **хуцын хуух** (хуцын төмсний гадуурхи арьс); **хуцын хуухнаг** (хуцын хуух); **хуцан хуулар** а м ь т а н (нэгэн зүйл бялзуухай, хушуу нь бүдүүн бөгөөд шар).

ХУЦАХ нохой чоно, үнэг хярс зэргийн амьтны хав хав гэж дуугарах; *нохой хуцах; үнэг хуцах*

ХУЦДАХ 1. хуц хөөх; 2. хуц дууриаж дарвих.

ХУЦСАХ хуц хүсэх, хуц эрэх.

ХУЦТАХ хуц дууриаж дарвих; *эр хонь хуцтах; хуцан хурга хуцтах.*

ХУЦУУЛАХ I хуцахын үйлдүүлэх хэв.

ХУЦУУЛАХ II дайсны нэргийг завдуулахгүй дарахаар гэнт довтлон дайрах.

ХУЧИАС юмыг хучих хучлага; *аргалын хучиас.*

ХУЧИАСЛАХ хучиасаар хучих, хучаастай болгох.

ХУЧИАСТАЙ хучиас бүхий; *хучиастай бараа; хучиастай нүүрс.*

ХУЧИГДАХ хучихын үйлдэгдэх хэв.

ХУЧИГДМАЛ хучигдсан юм; *хучигдмал байгаа эрдэнэс баялгийг хайж илрүүлэх хэрэгтэй байна.*

ХУЧИХ юмыг юм хумаар бүрхэх, дарах хураах зэргээр халхлах; *хувцас хөнжил мэтээр хучих; эсгийгээр хучих; дулаан хучиж унтах.*

ХУЧЛАГА дах дээл, хөнжил зэрэг хучих хэрэглэл; **хучлага дэвсгэр** х о р ш..

ХУЧЛАГАЛАХ хүүхэд төрсний дараа эхийнх нь хэвэл дотор хураамжлагдан өвдөх; *хучлагалж өвдөх.*

ХУЧУУЛАХ 1. хучихын үйлдүүлэх хэв; 2. хучигдах.

ХУШ у р г а м а л өндөр сугдалсан ихэмсэг сайхан бөгөөд мөнх ногоон нэгэн зүйл мод, самар ургана.

ХУШГА 1. модонд ургадаг жимс, хальс хатуу, цөмөө их бөгөөд тостой, идэхэд тааламжтай; **хушга харвах** (нэгэн зүйл тоглоом, олноороо нийлж нэг газар хушгыг өрж түүнийг хушгаар буюу бөмбөгөөр шидэж наадна): **хушганы цөм** (хушганы идээ); 2. эрийн өндөг, бэлгийн булчирхай, түүний уут.

ХУШИТ: хушит хамхаг у р г а м а л хужирлаг хөрсөнд ургадаг, жижигхэн үртэй, үрийг хуурч иддэг нэгэн зүйл ургамал.

ХУЯГ I 1. биеийг хамгаалахаар өмсөх элдэв хувцас; төмөрлөг, шир, мод зэрэг бат бэх юмаар хийнэ; 2. зарим амьтны биеийн гадуур хамгаалалт болж байдаг хайрс мэт юм; **лөвч хуяг, өвч хуяг** (бүх биеийг халхлах хуяг); **хөө хуяг** (хэлхсэн төмөр гархин хуяг); **бамбай хуяг** (халхавч хуяг).

ХУЯГ II ялтан хэрэгтнийг сахих харгалзах хүн; **хуяг харгалзагч** х о р ш.; *гяндны хуяг;* **хуяг эр** х у у ч и р с а н (сумын ардаас дайчлан татагдах цэрэг эр).

ХУЯГЛАХ I хуяг өмсөх.

ХУЯГЛАХ II ялт хүнийг сахиж сэргийлэх.

ХУЯГЛУУЛАХ хуяглахын үйлдүүлэх хэв.

ХУЯГТ хуяг бүхий; **хуягт арвай** (идээний гадуур нь хальсаар бүрхсэн арвай): **хуягт тэрэг** (цэрэг дайны хэрэгт зориулан хийсэн, хуяг бүрхүүлтэй автомашина); **хуягт загас** а м ь т а н (эрт дээр цагт амьдарч байсан, цээжин биедээ ясан хуягтай нэг зүйл загас).

ХУЯЛ хүсэл, тачаал, садар.

ХУЯЛТАХ аалигүй сэртэн зан гаргах.

ХУЯН I амьтны үе мөчний завсрын ус мэт зүйл ихсэснээс болж өвдөх өвчин; **хулуу хуян, хуян шар ус** х о р ш.; *хуян хөвөрөх; хуян хэрэх.*

ХУЯН II амьтны бие махбодид байдаг салтар судас мэт зүйл; *хааны хуян.*

ХУЯНТАХ хуян өвчтэй болох.

ХУЯНТУУЛАХ хуянтахын үйлдүүлэх хэв.

ХҮВРҮҮЛЭХ хүврэхийн үйлдүүлэх хэв.

ХҮВРЭЛ хүврэх үйлийн нэр, хүврэх үйлийн явц; **үр хүврэл** х о р ш..

ХҮВРЭЛДҮҮЛЭХ хүврэлдэхийн үйлдүүлэх хэв.

ХҮВРЭЛДЭХ хүврэхийн үйлдэлдэх хэв; *утас хүврэлдэх.*

ХҮВРЭХ I ургамлын өсөн үүсэх, ургаж өсөх; *ногоо хүврэх; тариа хүврэх.*

ХҮВРЭХ II атирсан, эвхэрсэн, зангирсан юм хүвэгдэн тэнийх, сунах, задрах, цуврах; *утас хүврэх; зангилаа хүврэх.*

ХҮВРЭХ III эсрэг салхинд түлхэгдэн зогсголзох.

ХҮВРЭЭ гүврүү, нухагдсан цохигдсоноос гарсан гувгар ором; *хүврээ гарах.*

ХҮВРЭЭТЭХ хүврээ гарах, хүврээтэй болох.

ХҮВЭР орчин өнхөрч дарах, хавтгайлах зэвсэг, чулуу буюу модоор хийнэ; *тарианы газрыг дарах хүвэр; зуурсан гурилыг элдэж хавтгайлах хүвэр;* **хүвэр мод** (элдүүр мод, гулууз).

ХҮВЭРДҮҮЛЭХ хүвэрдэхийн үйлдүүлэх хэв.

ХҮВЭРДЭХ 1. юмны захыг оёх утсыг захын дээгүүр дахин дахин давуулж нэг талаас хатгаж оёх; *эсгийний зах хүвэрдэх; арьс зүйж хүвэрдэх;* 2. ш и л ж с э н үүгээр түүгээр сэлгүүцэн явах; *айл хүвэрдэх; өрөө тасалгаа хүвэрдэх.*

ХҮВЭРДЭЭС хүвэрдэж оёсон оёдол; *хүвэрдээс нь ханзрах.*

ХҮВЭРДҮҮЛЭХ 1. хүвэрдэхийн үйлдүүлэх хэв; 2. хүвэрдэгдэх.

ХҮВЭРЛЭХ хүврээр дарах, элдэх; **элдэх хүвэрлэх** х о р ш.; *гурил хүвэрлэх.*

ХҮВЭРХИЙ юмны уяа зангилааг яг зангидахгүй татах, тайлахад хялбархан алдрахаар уясан уяа; *хүвэрхий зангидах.*

ХҮВЭХ атирсан эвхсэн утас дээс зэргийн юмыг татаж тэнийлгэх, сунгах, цувах.

ХҮГД зузаан хөвөнтэй өмд.

ХҮГДИЙЛГЭХ хүгдийхийн үйлдүүлэх хэв.

ХҮГДИЙХ хүгдгэр болох, бөгтийх; *цээж нь хүгдийх.*

ХҮГДГЭНЭХ хүгдгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ХҮГДГЭР хүн амьтны нуруу цээжин бие, хэвийн жишээнээс бөгтөр хэлбэртэй; *хүгдгэр цээжтэй хээр морь*

ХҮГДЭЛЗЭХ хүгдгэр юмны байн байн хөдлөх.

ХҮГЖ бүжиглэхэд дуулах дууллын аялгуу.

ХҮДВЭР худхэ, дорой, доромж; *худвэр ядуу; худвэр мохоо.*

ХҮДИЙ худэр: **худий луус** (элжигнээс төрсөн луус).

ХҮДЛЭГ хүний бүдүүн худхэ байдал; **худлэг нугас** (хээрийн нугасны өөр нэр).

ХҮДСЭХ могойн ус гатлах; *могой худсэх.*

ХҮДХЭ дорой ядуу, нунж, номой; **худвэр худхэ** хорш.; *худхэ будүүлэг; худхэ дорой.*

ХҮДХЭДЭХ хэтэрхий худхэ болох.

ХҮДХЭЛЭХ худхэ зан байдал гаргах.

ХҮДЭН агаарт тоос буюу утаа дэгдэн будантсан манан мэт юм; **манан худэн** хорш.; **худэн тунах** (тэнгэрийн уур газар буух ба газрын уур дэгжихгүй байх буюу гал түймрийн утаа алсаас ирж будан гэхэд биш бөгөөд чийггүй хуурай манан татах); **худэн татах** (худэн дэгдэн гарах).

ХҮДЭНТЭХ худэн татах, худэн тогтох, худэн суух.

ХҮДЭР I амьтан бугын нам, хөхөөр өсдөг, бие бага, эвэргүй, дээд эрүүндээ урт соёотой, эрийнх нь хүйсэнд заартай жижгэвтэр гөрөөс; **худэр шившүүрдэх** (худэр агнахад урьж исгэрэх); **зусаг худэр** (хоёр настай худэр): **худрийн заар** (эр худрийн хүйсний дотор хуралдсан анхилам үнэртэй бөөм юм; *хөлөрсөн хөлсий чинь үнэрлэвэл, худрийн заараас юуны өөр вэ* (ардын дуу).

ХҮДЭР II хүч тэнхээ сайтай, бие бялдар *чийрэг том;* **худэр чийрэг** хорш.; *худэр эр; худэр өвгөн.*

ХҮДЭР III төмөрлөгийн хольцтой чулуу; *зэсийн худэр; тугалганы худэр; соронзон худэр; төмрийн худэр; худрийн уурхай.*

ХҮЖ (ИН) I 1. үнэрт зүйлийг талхалж найруулан хийсэн нэгэн зүйл үнэртэн; *хүж шатаах;* **хүжний онгоц** (хүж агуулах уртхан сав); **хүжний хатгуур** (хүжийг босгож хатгах хэрэгсэл); 2. анхилам сайхан үнэртний зүйл; **үнэртэн хүжис** хорш.: ☆ **хүж өвс** ургамал (үндэснээс дээш босоо жагсан ургана, ишийн дагуу босоо ургасан харавтар ногоон навчтай, шар цэцэгтэй нэгэн зүйл ургамал); **хүж хорхой** амьтан (хүж мэт уртлаг хэлбэртэй нэг зүйл шимэгч хорхой, бохир ус идээгээр дамжин хүн малын гэдсэнд орж бойжно); **хүжин зүлгэч** амьтан (цууцлайтай адил нэг зүйл бялзуухай, хөдөө газар оршино).

ХҮЖ II элдэж боловсруулсан бүхэл бүтэн арьсан эд; *хүж булигаар; хүж илэг; хүж сарьс; хүж сааръ.*

ХҮЖЛЭГ: хүжлэг хулгана амьтан эрхий хуруу мэт том бөгөөд нүх ухахдаа хурдан нэг зүйл хулгана.

ХҮЗҮҮ 1. хүн амьтны толгой сээр хоёрын хооронд залгалдан орших хэсэг, түүний арьс шир; *хүзүүний мах; оонын хүзүүгээр хийсэн хуйв; хүргэн хүний хүзүү нь бөх, хүний малын нуруу нь бөх* зүйр; **аман хүзүү, амаргал хүзүү** (толгойн тулгуур хүзүү); **хатан хүзүү** (аман хүзүүний дараахь хүзүү); **долоон хүзүүт** (өндөр хүзүүтэй); **хүзүүний ороолт** (хүзүү болон толгой орох эд юм); **хүзүү гоётох** (хүзүү хөндүүр болох); **хүзүүн дээр нь сандайлах** (эзэрхэн дээрэнгүйлж дарлах); **аман хүзүү зангидах** (ороон сүлжиж зангилах); 2. савны амсар талын буюу өөр зарим нэгэн юмны нарийн шувтан этгээд; *лонхны хүзүү; хөхүүрийн хүзүү.*

ХҮЗҮҮВЧ I 1. тэрэг чарга хөллөх морь малын хүзүүнд хийж арал оосор торгох хэрэглэл; *морины хүзүүвч;* 2. амьтны хүзүүнд уях торгох буюу тэмдэг чимэг болгож зүүсэн оосор; *тугалын хүзүүвч; нохойн хүзүүвч; хүв хүзүүвч; хүзүүвч чимэг.*

ХҮЗҮҮВЧ II 1. уул хярын үзүүр шувтрагын ойр бүхий бяцхан хөтөл онь; *уулын хүзүүвч; хүзүүвчээр давах;* 2. гэр байшин хоёр буюу хоёр байшингийн хооронд холбосон бяцхан пин мэт юм; *гэрийн хүзүүвч; байшингийн хүзүүвч;* 3. хоёр юмны хооронд холбосон нарийн зурвас юм; *нуурын хүзүүвч; газрын хүзүүвч.*

ХҮЗҮҮВЧЛҮҮЛЭХ 1. хүзүүвчлэхийн үйлдүүлэх хэв; 2. хүзүүвчлэгдэх.

ХҮЗҮҮВЧЛЭХ хүзүүнд оосор чимгийн зэрэг юм уях, хүзүүвч хийх.

ХҮЗҮҮДҮҮЛЭХ 1. хүзүүдэхийн үйлдүүлэх хэв; 2. хүзүүдэгдэх.

ХҮЗҮҮДЭХ хүзүүнээс барих, хүзүүгээр нь тэврэх; *тугал хүзүүдэх; хүүхэд, аавыгаа хүзүүдэх.*

ХҮЙ I хүн амьтны хүйс; **хүй татах** (төрөл ургаа дотночлох); **хүй тасрах** (төрлийн үе холбоо тасрах, үр үндэс нь тасрах); **хүй цөглөх** (хүүхдийн хүй унах); **хүй зузаан (а, ах**

дүү өнөр олуулаа; б. хүй бүтэн); **хүй бүтэн, хүй сайтай** (ур хүүхэд нь эндээгүй бүрэн): **хүй бөхтэй** (хүй бүтэн бүрэн); **хүй муутай** (ур хүүхэд нь хэврэг); ☆ **хүй нэгдэл** (хүн төрөлхтний түүхэн дахь нийгэм-эдийн засгийн анхны байгуулал).

ХҮЙ II хүн амьтан буюу мод ургамал мэтийн олноор цугларсан бөөгнөрсөн хэсэг бүлэг юм; *хүй олон хүн; хүй хүйгээр хэсэг мод; нэг хүй айл; хүй хүйгээр ургах;* **хүй хүйгээр** (бөөн бөөнөөр, их ихээр; *хүй хүйгээр юм авах; хүй хүйгээр дүйж худалдах);* **хүй хүй салхилах** (салхи үе үе бүр хийн салхилах).

ХҮЙДЭС малын хөлдүү баас, хөлдүүс ч гэдэг; *хотны хүйдэс арилгах.*

ХҮЙДЭХ хөвчилсөн нумны хөвчийг хөвчлүүрээс угцруулан авч хариулах; *нум хүйдэх.*

ХҮЙЛС хоёр усны хоорондын бяцхан зурвас хуурай газар; *усны хүйлс; голын хүйлс.*

ХҮЙЛЭХ зарим амьтны цагаар отлох; *чоно хүйлэх; нохой хүйлэх.*

ХҮЙР нумны хөвчний дээд доод хоёр үзүүрт зангиаслан залгаж хичирт торгох оосор, хөвчний хичир ч гэдэг.

ХҮЙС (ЭН) I амьтны эхээс төрөхдөө ихэстэй холбоотой гардаг судал хүй; хүний хүйс хонхор, бусад амьтны хүйс тэгш буюу бяцхан товгор байдаг; **хүй хүйс** х о р ш.; **хүйсний цөнхрөг** (хүний хүйсний нүх); **хүйс татах** (төрөл угсааг бодож дотнолон үзэх); **хүйс тэмтрэх** (хүн амьтныг аймаг бүлгээр буюу гэр өрхөөр ба төрөл угсаагаар эсэхүл нутаг үндсээр нь дуусган алж арилгах).

ХҮЙС II хүн адгуус амьтны эр эмийг; *эр хүйстэй бухнийг; эр хүйстэй бухнийг тоолох хэрэгтэй;* **хэл зүйн хүйс** (хэл зүйн талаар үгсийн эр эмийг ангилах ангилал).

ХҮЙС III 1. ургамал жимс зэргийн иш тогтсон газрын тус байх төв гол; *цэцгийн хүйс;* 2. зарим юмны гол төвийг эзэлсэн зүйл; *тогооны хүйс; нуурын хүйс; далайн хүйс.*

ХҮЙТ хүйтэн; **хүйт авах** (салхи авах, салхинд цохигдох): **хүйт даах** (а. хүйтэнд тэсвэрлэх; б. хүйтэн жиндүү болох); **хүйт орох** (хүйтэрч эхлэх); **хүйт оргих** (хүйтэн байдалтай болох).

ХҮЙТДҮҮЛЭХ хүйтдэхийн үйлдүүлэх хэв.

ХҮЙТДЭХ хүйтэн нь нэндэж тохиромжгүй болох; *цай хүйтдээд ууж болохгүй байна.*

ХҮЙТРҮҮЛЭХ хүйтрэхийн үйлдүүлэх хэв.

ХҮЙТРЭХ цаг улирлын уур амьсгал хүйтэн болж хувирах; *ойрын хэд хоног их хүйтэрч байна.*

ХҮЙТХЭН баахан хүйтэн.

ХҮЙТШИХ хүйтний шинж орох; *цаг хүйтшиж байна.*

ХҮЙТЭВТЭР арай хүйтэн, нилээд хүйтэн.

ХҮЙТЭВТЭРХЭН баахан хүйтэвтэр, нилээд хүйтэвтэр; *энэ өдөр хүйтэвтэрхэн байна.*

ХҮЙТЭН I 1. халуун гэдэгтэй эсэргүүцэлдсэн утга, юмны сэрүүн жихүүний нь; *өвлийн хүйтэн; харзны хүйтэн ус; уулын хүйтэн салхи; голын хүйтэн жавар; байшин хүйтэн байна; хүйтэн зуух; хүйтэн хоол;* **бага хүйтэн** (сарны зурхайн ёсны жилийн хорин дөрвөн улирлын нэг, өвлийн туйл, ес эхлэхийн өмнөхөн үе); **их хүйтэн** (сарны зурхайн ёсны хорин дөрвөн улирлын нэг, өвлийн туйл, хоёр гурав дөрвөн ес буюу идэр гурван ес); **хүйтэн шүүдэр** (сарны зурхайн ёсны хорин дөрвөн улирлын нэг, чийг унах цаг); **хүйтэн зэвсэг** (хутга мэс, жад сэлэм зэрэг галт биш зэвсэг); **хүйтэн дайн** (үзэл суртлын тэмцэлдээн): **хүйтэн цуст амьтад** (биеийн халуун хүйтэн нь орчин тойрноос шалтгаалан өөрчлөгдөж байдаг загас, газар усныа явагч амьтад); 2. хүний ойшоомжгүй, тааламжгүй байгаа мөртөө засдаглаж байгаа байдлы нь; *хүйтнээр инээх; хүйтэн харц гаргах; хүйтнээр уулзах; хүйтэн инээд хүрэх; юманд хүйтнээр хандах;* **хүйтэн сэтгэл** (буруу муухай, хар хорон санаа сэтгэл); **хүйтэн санаа** (хүйтэн сэтгэл).

ХҮЙТЭН II хүний бэлгийн эрхтний орчин гарах нэг зүйл халдварт өвчин; **заг хүйтэн, шүүрэг хүйтэн, яр хүйтэн** х о р ш.;

ХҮЙТЭНДҮҮЛЭХ хүйдэндэхийн үйлдүүлэх хэв.

ХҮЙТЭНДЭХ хэтэрхий хүйтэн болох.

ХҮЙТЭНТҮҮЛЭХ хүйтэндэхийн үйлдүүлэх хэв.

ХҮЙТЭНТЭХ хүйтэн өвчин тохиох.

ХҮЛГЭЛЗҮҮЛЭХ хүлгэлзэхийн үйлдүүлэх хэв.

ХҮЛГЭЛЗЭХ баахан хүлээх; *бяцхан түдэсхийн хүлгэлзэх алгуураар явж хүлгэлзэх.*

ХҮЛС хүж үнэртэн шатаах нэгэн зүйл сав, төмөрлөгөөр хийнэ, хэлбэр олон янз, бойпор; ☆ **хүлс цэцэг** у р г а м а л (цагаан цэцэгтэй, хүйс их бөгөөд хоовон хэлбэртэй нэгэн зүйл цэцэг).

ХҮЛТГЭР ёс мэддэггүй бүдүүлэг.

ХҮЛТИЙХ ёс мэдэхгүй бүдүүлэг байдал гаргах.

ХҮЛТЭГ хүүхдийн шээс тосох сав.

ХҮЛТЭГНЭХ хүн амьтны ихэд эмээж, уруу байдал гаргах; **хүлтэгнэх халтганах** х о р ш..

ХҮЛҮҮЛЭХ 1. хүлэхийн үйлдүүлэх хэв; 2. хүлэгдэх.

ХҮЛХГЭР хүн амьтны бие, хэвэл этгээдээр нэндүү бүдүүн хэлхгэрий нь; **хүлхгэр халхгар** х о р ш.; *хүлхгэр биетэй амьтан; дээл хувцас элбэгдэж хүлхгэр болох.*

ХҮЛХГЭРДҮҮЛЭХ хүлхгэрдэхийн үйлдүүлэх хэв.

ХҮЛХГЭРДЭХ хэтэрхий хүлхгэр болох.

ХҮЛХИЙЛГЭХ хүлхийхийн үйлдүүлэх хэв, хүлхгэр болгох.

ХҮЛХИЙХ хүлхгэр болох; *гэдэс нь хүлхийх; дээл хүлхийх.*

ХҮЛХҮҮЛЭХ хүлхэхийн үйлдүүлэх хэв.

ХҮЛХЭГНҮҮЛЭХ хүлхэгнэхийн үйлдүүлэх хэв.

ХҮЛХЭГНЭХ хүлхгэр юмны хүлхэг хүлхэг хөдлөх.

ХҮЛХЭЛЗЭХ хүлхгэр юмны хүлхэс хүлхэс хөдлөх.

ХҮЛХЭХ юмыг аман дотроо зажлахгүй займчуулан агуулах; *ааруул хүлхэх; чихэр хүлхэх.*

ХҮЛЦҮҮЛЭХ хүлцэхийн үйлдүүлэх хэв.

ХҮЛЦЭЛ хүлцэх үйлийн нэр: **хүлцэл тэсвэр** х о р ш.; **хүлцэл өчих** (уучлал гуйх).

ХҮЛЦЭЛГҮЙ хүлцэл муутай, тэсвэр хатуужилгүй.

ХҮЛЦЭЛТ хүлцэл тэсвэр бүхий, хүлцэнгүй.

ХҮЛЦЭНГҮЙ хүлцэх тэсвэр сайтай, тэвчээр хатуужил сайтай.

ХҮЛЦЭХ ямар нэгэн хилэгнэлтэй, хорсолтой халтай зүйл тохиолдовч түвдэн тэсвэрлэх, баггаан аваачих; **хүлцэх тэсвэрлэх** х о р ш.; *зовлон бэрхшээлийг хүлцэж өнгөрүүлэх хэрэгтэй.*

ХҮЛЭГ I хөлөг.

ХҮЛЭГ II хүлэх уях хэрэглэл; **уяа хүлэг** х о р ш.; *хүлэг сур; хүлэг дээс.*

ХҮЛЭГЛЭГ хөлөглөг.

ХҮЛЭГЧИН хөлөгчин.

ХҮЛЭМЖ газар ухаж хийсэн нүхэн гэр; **цэцгийн хүлэмж** (цэцэг ургуулах дулаан байр); 2. цонхгүй хийсэн оромж.

ХҮЛЭР I хүрэл.

ХҮЛЭР II намгийн ургамлын ялзармалаас бүрэлдэн тогтсон нягт цул зүйл, түлшинд хэрэглэнэ.

ХҮЛЭХ юмыг боох баглах, агдлах; *хүнийг агдалж хүлэх; морь малыг хүлэх; юмыг баглаж хүлэх.*

ХҮЛЭЭ хүлэг; **уяа хүлээ; баглаа хүлээ** х о р ш ..

ХҮЛЭЭГДҮҮЛЭХ хүлээгдэхийн үйлдүүлэх хэв.

ХҮЛЭЭГДЭЛ хүлээгдэх үйлийн нэр; **хүлээгдэл чирэгдэл** х о р ш..

ХҮЛЭЭГДЭХ хүлээхийн үйлдэгдэх хэв.

ХҮЛЭЭЛГЭХ хүлээхэд хүргүүлэх.

ХҮЛЭЭС 1. багласан, хүлсэн юм; **баглаас хүлээс** х о р ш.; *хүлээстэй эд юм; хүлээстэй амьтан; хүлээсий нь тайлах;* 2. ш и л ж с э н автагдсан эрхшээл нөлөө; *орилонгийн хүлээс; мухар сүсгийн хүлээс; дарлал мөлжлийн хүлээс.*

ХҮЛЭЭСЛЭХ хүлээстэй болгох, хүлэх.

ХҮЛЭЭТЭЙ хүлэг, хүлээс хүлээ, бүхий

ХҮЛЭЭХ I саатах, хүлгэлзэх; *ирэх одохыг хүлээх; цаг хэмийг хүлээх; би чамайг хүлээж ядав; маргааш болтол хүлээх хэрэгтэй; юм хүлээхэд цаг дөхөхгүй юм.*

ХҮЛЭЭХ II биедээ дааж авах, тосч авах; *дуртайяа дагаж хүлээн авах; тулгагдаж хүлээн авах; гэм бурууг хүлээх; хэрэг хүлээх; ял хүлээх; алба хүлээх; хариуцлага хүлээх; таны явуулсан захидлыг бид хүлээн авав;* **хүлээн авах** (биеэр учирч уулзах; *зочид хүлээн авах);* **хүлээн авалт** (зочин гийчин, албаны хү-

мүүс зэргийг хүндэтгэн дайлах дайллага; *Засгийн газрын хүлээн авалт);* **хүлээн авагч** (а. юм хүлээн авах этгээд; *ноос хүлээн авагч;* б. радиогоор явуулж байгаа дуу, сигнал хүлээн авах аппарат хэрэгсэл).

ХҮМ: **юм хүм** юм; *юм хүмээ янзлах хэрэгтэй.*

ХҮМБАРАА: **хүмбараа матар** амьтан усанд амьдардаг бөгөөд хуурай газар өндөглөдөг, халуун орны хэвлээр явагч том амьтан.

ХҮМҮҮС олон хүн; *ажлын чадвартай хүмүүс; манай гэр бүлийн хүмүүс; хариуцлагатай хүмүүс.*

ХҮМЭЭЛ ургамал тал хээр ургадаг сонгинын төрлийн ургамал, сонгино мэт амт үнэртэй бөгөөд малд сайн тэжээл болно, үүгээр бас сорс хийнэ.

ХҮМЭЭС ургамал идэр ногооны адил, навч нь арай том, савх шиг иштэй, үзүүртээ шар цэцэгтэй нэгэн зүйл ногоо.

ХҮН I 1. багаж зэвсгийг бүтээж түүнийгээ нийгмийн хөдөлмөрийн үйл ажиллагаанд хэрэглэж чаддаг, хэл, сэтгэхүйг эзэмшин амьдрагч нар; *манай оронд хүн хүнийгээ дарлах мөлжих ёс нэгэнт усдасан; танихгүй хүн; морьтой хүн ирэв; тэр хүнээс асуу; зан сайтай айлд хүн болгон цугладаг, замаг сайтай усанд шувуу болгон цугладаг* зүйр; *хүн ахтай дээл захтай* зүйр; *хүн чадлаараа, хүлэг морь хурднаараа* зүйр; *хүн болгон адилгүй хүлэг болгон жороогүй* зүйр; *хүн сэцэн ч хэлэхээс наашаа санахгүй, цаас нимгэн ч чичихээс наашаа цоорохгүй* зүйр; **хүн төрөлхтөн** (бүх хүн тоотон; *хүн төрөлхтний түүхэнд);* **хүн хар** (хүн амьтан, хүн юм; *хүн хар алга уу? хүн хар үзэгдэхгүй байна);* **хүн болох** (хүний зэрэгт хүрэх; *хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа* зүйр;) **баян хүн** (хөрөнгө чинээ сайтай хүн; *баян хүн бачтай);* **хоосон хүн** (хөрөнгө чинээ ядуу хүн; *хоосон хүн хочтой);* **хүн бүл** (нэг гэрийн доторхи хүмүүс); **сайн хүн** (хүн сайтай, тусчхан): **сайхан хүн** (үзэмж, үзэсгэлэн сайтай хүн); **хүн сайтай** (ханилгаа нөхрийн мөс чанар сайтай); **хүн муутай** (ханилгаа, нөхрийн мөс чанар муу); **хүний ёс** (хүнийг хайрлах, хүндэтгэх ёс); **хүний чанар** (хүний сайн муу санаа); **хүний үнэргүй** (маш муу санаатай, ямар ч муу хэрэг үйлдэхээс бүцахгүй хүн); **муу хүн** (хар хорон санаатай хүн); **зэрлэг хүн** (бүдүүлэг хүн: *энэ яасан зэрлэг хүн бэ!);* **муухай хүн** (а. үзэмж үзэсгэлэн муутай; б. хүнлэг чанар муутай; *аваад яв гээд байхад орхиод явдаг яасан муухай хүн бэ);* **сонин хүн** (этгээд, хачин, янзын хүн); **бөх хүн** (бяр тэнхээ ихтэй, барилддаг хүн); **бүсгүй хүн** (эмэгтэй хүн); **бүстэй хүн** (эрэгтэй хүн); **хар хүн** (а. лам биш хүн; *төрийн хар хүн;* б. эмэгтэй хүний эр нөхөр; *манай хар хүн хөдөө явсан);* **хүн ам** (улс, алив тодорхой хүрээ хязгаар заагт амьдран суугчид; *хотын хүн ам; хүн амын бүртгэл; хүн амын данс; хүн амын тооллого; хүн амын судалгаа);* **хүн чулуу** (хүн дүрст хөшөө); **хүн хар гөрөөс** (алмас): **хүн од** зурхай (тэнгэрийн оёдлын ойр орших нэгэн сүрэг таван од); **хүн эм, хүн орхоодой, хүн өвс** ургамал (иш өндөр хоёр тохой илүү, салаа нь тав зургаа орчим бөгөөд тойрон ургана, нэг салаанд таван навч бий, цэцгийн үр цөм улаан, эмнэлэгт хэрэглэдэг цухаг ургамал); **хүн мод** (тэмээг ганц хүн ачихад нөгөө тэнг шордож тогтоох хүртэл түр тавих олс татсан, ацтай, тавиур мод); 2. гаднын, өөрийн биш, бусдын; *хүнийд намар, өөрийнд хавар* зүйр; **хүний амаар будаа идэх** (бусдын хэлснийг өөрийн үг болгож явах); **хүний гараар могой барих** (өөрийн санасныг бусдаар хийлгэх); **хүний хүн** (гаднын хүн): **хүний юм** (бусдын юм).

ХҮН II хүний дээд уруулын хонхор.

ХҮНГҮЙ 1. хүн байхгүй, эзгүй; *хүнгүй газар; хүнгүй айл;* 2. хүн бүл дутмаг; *ажиллах хүнгүй айл.*

ХҮНГЭНҮҮЛЭХ хүнгэнэхийн үйлдүүлэх хэв.

ХҮНГЭНЭЛДЭХ хүнгэнэхийн үйлдэлдэх хэв.

ХҮНГЭНЭХ нүргээн ихтэй, хүн хүн гэсэн чимээ сонсдох; *газар хүнгэнэж байна; салхи хүнгэнэтэл салхилав; нэг өвгөн хүнгэнэтэл ярьж гарав; хэнгэрэг хүнгэнэн дуугарч байв.*

ХҮНГЭРДЭХ нууж далдлахгүй ярих.

ХҮНГЭРСЭХ дууны үргэлжлэн гарах.

ХҮНД I 1. чанар хөнгөнгүй, жинтэй; *хүнд ачаа; хүнд чулуу; хүндийн жин;* **хөл хүнд** (бие жирэмсэн); **хүнд аж үйлдвэр, хүнд үйлдвэр** (машина, үйлдвэрлэлийн хэрэгсэл, илч хүчин, түлш үйлдвэрлэх үйлдвэр); 2. хөдлөх аашлах байдал удаан назгай; *хүнд хүн; хүнд назгай; хүнд бөгстэй;* **хүнд суртал** (албан хэрэгт түшмэлийн арга барилаар хандах хандлага); **хүнд сурталтан** (хүнд суртлыг баримтлагчид); 3. шилжсэн хялбар биш, хүчир, хэцүү; **хүнд хүчир** хорш.; *хүнд ажил; хүнд*

хүчир үйл явдал; хүнд шархдах; хүнд өвчин; 4. ш и л ж с э н ноц холбогдол их; *хүнд хэрэг; хүнд ял; хүнд холбогдол; хүнд хариуцлага.*

ХҮНД II нэр, алдар: **нэр хүнд, алдар хүнд** х о р ш.; *хүндтэй хүн; нэр хүнд нь дээшилж яваа; ард түмний дотор итгэл хүндийг олох.*

ХҮНД III х у у ч и р с а н урьдын цагт сумын зангийн дараахь албан тушаал; *сумын хүнд; хушууны хүнд.*

ХҮНДГҮЙ нэр хүнд нь буурах, доройтох; *олонд хүндгүй болох; нэр хүндгүй болгохыг оролдох.*

ХҮНДДҮҮЛЭХ хүнддэхийн үйлдүүлэх хэв.

ХҮНДДЭХ хэтэрхий хүнд болох; *ачаа хүнддэх; үүрэг хариуцлага хүнддэх.*

ХҮНДЛҮҮЛЭХ 1. хүндлэхийн үйлдүүлэх хэв; 2. хүндлэгдэх.

ХҮНДЛЭГДЭХ хүндлэхийн үйлдэгдэх хэв.

ХҮНДЛЭЛ хүндлэх үйлийн нэр.

ХҮНДЛЭМДЭХ бусдыг хүндлэхэд дуртай байдал гаргах.

ХҮНДЛЭХ хүндтэйд үзэж ёс журмыг гүйцэтгэх; *эцэг эхийг хүндлэх; эрдэмтнийг хүндлэх; настныг хүндлэх; ахмад тушаалтныг хүндлэх; зочдыг хүндлэх.*

ХҮНДРҮҮЛЭХ хүндрэхийн үйлдүүлэх хэв; хүнд болгох; *өвчнийг хүндрүүлэх; үүрэг хариуцлагыг хүндрүүлэх.*

ХҮНДРЭХ 1. хүнд болох; *ажил хүндрэх; ачаа хүндрэх; алба хүндрэх;* **хөл хүндрэх** (жирэмсэн болох); 2. өвчин ихсэх; *хориотой хоол идээд өвчин улам хүндрэв.*

ХҮНДСҮҮЛЭХ хүндсэхийн үйлдүүлэх хэв, улам хүнд болгох.

ХҮНДСЭХ хүндтэх.

ХҮНДТЭЙ хүндэлбэл зохих шалтгаан бүхий; *хүндтэй хүн.*

ХҮНДТЭХ улмаар хүнд болох.

ХҮНДХЭН баахан хүнд, арай хүнд.

ХҮНДШЭЭХ эрхэмлэн дотнолж хүндтэйд үзэх.

ХҮНДЭВТЭР арай хүнд.

ХҮНДЭД хүндээр; *хүндэд жанчих; хүндэд өвдөх.*

ХҮНДЭТ хүнд бүхий, эрхэмлэн хүндэтгэвэл зохих хүн; *хүндэт тэргүүлэгч; хүндэт удирдагч; хүндэт гишүүн; хүндэт нөхөр;* **хүндэт самбар** (гарамгай байгууллага, хүмүүсийн алдар нэр, мөн зургийг хадсан самбар).

ХҮНДЭТГЭЛ хүндэтгэх үйлийн нэр; *хүндэтгэл хүлээх.*

ХҮНДЭТГЭХ эрхэм чухал болгож хичээнгүйлэн хүндэлж үзэх; *хүндэтгэн ёслох; хүндэтгэн цайлах; хүндэтгэн бараалхах; хүндэтгэн үзэх шалтгаантай эсэхийг шалгах.*

ХҮНЖ хүнцэл.

ХҮНЖИД у р г а м а л гүнжид; *гүнждийн үр; гүнждийн тос.*

ХҮНИЙРХҮҮ өөриймсөг биш зан байдал гаргамтгай; *хүнийрхүү зан гаргах.*

ХҮНИЙРХҮҮЛЭХ хүнийрхэхийн үйлдүүлэх хэв.

ХҮНИЙРХЭГ хүнийрхүү зантай.

ХҮНИЙРХЭХ таньж дасаагүй буюу үзээгүй айл оронд бүшүүрхэж хүнийрхүү зан байдал гаргах, юманд өөриймсөг биш байдалтайгаар хандаж харилцах, ажиллах; *хүнийрхэх хэрэггүй.*

ХҮНИЙХ бусдынх, манайх минийх биш; *малгай тавивал манайх, маргааш явбал хүнийх з үй р.*

ХҮНС (ЭН) хүмүүсийн хэрэглэх хоол ундны зэрэг зүйл; **хоол хүнс; хүнс тэжээл** х о р ш.; *хүнс бэлтгэх; хүнс сайтай яваарай; хүнсний үйлдвэр; хүнсний дэлгүүр; хүнсний малаа туугаад явав; хүнсний чанарыг сайжруулах хэрэгтэй.*

ХҮНСЖИХ хүнстэй болох.

ХҮНСЖҮҮЛЭХ хүнсжихийн үйлдүүлэх хэв.

ХҮНСЛЭГ хүнсний зүйлээр хангалуун.

ХҮНТЭЙ 1. хүн бүхий, эзэн бүхий; 2. хүн бүл сайтай.

ХҮНХГЭР хүнхэр, хонхгор.

ХҮНХИЙЛГЭХ хүнхийхийн үйлдүүлэх хэв.

ХҮНХИЙХ хонхор хүнхэр болох.

ХҮНХРЭЭ I монгол гэрийн хаалган тал буюу хана хаалга хоёрын уулзар газар; *хүнхрээ нь буух; хүнхрээ нь орох.*

ХҮНХРЭЭ II үнээний сүүлийн самсааны хоёр этгээд дахь хөвчилсөн булчин мах; *хүнхрээ нь зөөлрөх; хүнхрээ нь сэтрэх.*

ХҮНХЭР хонхор болсон нь; **хүнхэр хонхор** хорш..

ХҮНХЭРДЭХ 1. хэтэрхий хүнхэр болох; 2. эрээ цээргүй хэлэлцэх.

ХҮНХЭРСЭХ 1. хүнхэр болох; 2. дуу чимээний үргэлжлэх.

ХҮНХЭЭЛ ургамал сонгинын адил бөгөөд элсэнд ургадаг, бяцхан нэгэн зүйл ногоо, идэж хэрэглэдэг.

ХҮНЦЭЛ нэг зүйл үр, хэлбэр дүгрэг, хавтгай, амт маш гашуун, хортой, эмнэлэгт хэрэглэнэ, гожил ч гэдэг; *хүн хэлбэл өвөрт, хүнцэл идвэл арааид.*

ХҮР I: **хүр дүү** гэрийн дүү нар; **хүр дүү бэр** (гэргийн дүүгийн гэргий); **хүр охин дүү** (гэргийн охин дүү).

ХҮР II: **хүр хорхой** амьтан 1. тариаланг сүйтгэгч нэгэн зүйл хорхой, өнгө хар, бие урт, олон хөлтэй; 2. шөнийн эрвээхийн нам, ёнхор мяндас авна, торгоны хорхой ч гэнэ.

ХҮР III: **хүр бөх** ургамал иш нарийн, үзүүртээ салаатай, цагаавтархан цэцэгтэй, сүлжиж сэгс сав хийж болдог нэг зүйл өвс.

ХҮР IV ганга; гуу; *голын хүр дор хэдэн үхэр харагдана.*

ХҮР V бүх, бүгд; *хүр их улс.*

ХҮРВЭШ: чонын хүрвэш биеэр жижигхэн бэржрүү туурч загатнах өвчин.

ХҮРГҮҮЛЭХ 1. хүргэхийн үйлдүүлэх хэв; 2. хүргэгдэх.

ХҮРГЭГДЭХ хүргэхийн үйлдэгдэх хэв.

ХҮРГЭГЧ хүргэх үйл гүйцэтгэгч, шуудан хүргэгч, хүргэж өгөх үүрэг гүйцэтгэдэг хүн.

ХҮРГЭН охины ханилсан нөхөр; *хүргэн хүү; хүргэн ах; хүргэн дүү.*

ХҮРГЭХ хүрэхэд хүргүүлэх; 1. хүрэлцэх; **гар хүргэх** (алив юмыг гараар хүрэлцэх, барих, хөдөлгөх; *энэ шилтэй хүчилд гар хүргэж болохгүй шүү);* **ам хүргэх** (амсах): 2. илгээх, явуулах, өгөх; *бичиг хүргэх; бэлэг хүргэх; захидал хүргэх; хүргэж өгөх; төрхөмд нь хүргэх;* 3. тулгах; *туйлд нь хүргэх; санасанд нь хүргэх; эцэст нь хүргэх;* 4. мэдэгдэх; *хэл хүргэх; сонорт хүргэх; мэнд хүргэх;* 5. илэрхийлэх; *гашуудал хүргэх; баяр хүргэх;* 6. учруулах; *тус хүргэх; хор хүргэх; гэм хүргэх;* 7. өрнүүлэх; *инээд хүргэх; дур хүргэх; нойр хүргэх; уур хүргэх.*

ХҮРД I 1. тэнхлэгт хэлхэж орчих, өнхрөх хэрэглэл буюу өнхрөхгүй боловч дур байдал адил зарим юм; *тэрэгний хүрд; оньст хүрд; тоононы хүрд;* 2. шашны ёсны буян санаж эргүүлдэг, тэнхлэгт ороосон ном; *хүрд эргүүлэх.*

ХҮРД II 1. амьтан өтөг буудад орших нэгэн зүйл хорхой, өвөл ичнэ, хонь малыг идэж зутруулна; 2. амьтан хатсан мах, түүхий арьс зэргийн юманд төрөх, элгэн тал нь цагаан, нуруун тал нь харавтар өнгөтэй хорхой.

ХҮРДЛЭХ I орчих хүрд болгон хийх.

ХҮРДЛЭХ II хүрд хорхой бий болох.

ХҮРЖИГНҮҮЛЭХ хүржигнэхийн үйлдүүлэх хэв.

ХҮРЖИГНЭХ хүр хүр хийсэн чимээ үргэлжлэн сонсдох; *тэнгэр хүржигнэн дуугарах; мягуй хүржигнэн дуугарав.*

ХҮРЗ (ЭН) юмыг хамах хусах зэвсэг; *төмөр хүрз; модон хүрз; нэг хүрз шороо хаях.*

ХҮРЗДҮҮЛЭХ хүрздэхийн үйлдүүлэх хэв.

ХҮРЗДЭХ хүрзээр ухах, малтах; *хүн бүхэн арав-арав хүрздэх ёстой.*

ХҮРМЭЛ ургамал хотгор газар ургадаг бөгөөд иш өндөр нэг зүйл өвс; **хүрмэл гэр** (хүрмэл өвсөөр хийсэн гэр овоохой).

ХҮРНЭ амьтан суусрын язгуурын бяцхан, араатан амьтан, үнэр өмхий; өмхий хүрэн ч гэнэ.

ХҮРТВЭР 1. хүртсэн юм; *хүртвэр нь бага байна;* 2. ногдвор; *арван хоёрыг хоёрт хуваахад хүртвэр нь зургаа болно.*

ХҮРТҮҮЛЭХ хүртэхийн үйлдүүлэх хэв.

ХҮРТЭЛ хүрэх болтол; *үд хүртэл; орой хүртэл; нөгөөдөр хүртэл; манайхыг хүртэл; хүүхэд багачуудаас аваад өвгөд хөгшид хүртэл; хамгийн багаас эхлээд хамгийн их хүртэл; намаас өндөр хүртэл; нарийнаас өргөн хүртэл; дороос дээр хүртэл.*

ХҮРТЭМЖ хүртэх хүрэлцэх хэмжээ; хүртээмж ч гэдэг; *хүртэмж сайтай; хүртэмж муутай.*

ХҮРТЭМЖГҮЙ хүртэмж багатай, хүртэмж муутай.

ХҮРТЭМЖТЭЙ хүртэмж ихтэй, хүртэмж сайтай.

ХҮРТЭХ I 1. юмыг олонд хуваахад ногдох хувь хүрэлцэх; **ногдох хүртэх** х о р ш.; 2. хүндэтгэвэл зохих юмнаас онцлон үзэж ямар нэгэн зүйлийг олгох; *засгийн хайр хэшиг хүртэх; гавьяа шагнал хүртэх; өршөөл хүртэх;* 3. хүрэлцэх, гүйцэлдэх, хүрэх; *ухаан хүртэхгүй хэрэг; олон хүүхдийн өмсөх идэх нь хүртэхгүй юм; чамд хувь хүртэх биз.*

ХҮРТЭХ II хүртэхгүй.

ХҮРТЭХҮЙ мэдрэхүй таван эрхтний дотор хи биеийн хүрэлцэхүйн сэрэгдэхүүн; *хүртэхүй мэдрэл.*

ХҮРТЭЭЛ хүртэх үйлийн нэр, юмны хүртэх хүртээмж.

ХҮРТЭЭЛГҮЙ 1. хамаагүй, холбогдолгүй; *энэ хэрэг чамд хүртээлгүй;* 2. хүртэмж муутай.

ХҮРТЭЭЛТЭЙ 1. олон юманд орж хүрэлцэх сэхээ самбаатай; *хүртээлтэй хүн;* 2. хүртэмж сайтай, хүрэлцээтэй; *хүртээлтэй юм.*

ХҮРТЭЭМЖ юмыг хуваасны ногдлын хувь, хүртэмж ч гэнэ; *хүртээмж сайтай; хүртээмж муутай.*

ХҮРТЭЭХ 1. хүртээхэд **хүрүүлэх**; 2. гүгээж олгуулахын хүндэтгэл.

ХҮРҮҮЛЭХ хүрэхийн үйлдүүлэх хэв, хүргэх.

ХҮРХРҮҮЛЭХ хүрхрэхийн үйлдүүлэх хэв.

ХҮРХРЭХ амьтны хүрчигнэн дуугарах чимээ; *буур хүрхрэх; барс хүрхрэх.*

ХҮРХРЭЭ хэц хавчил газраас доош сочмог ширүүн цутган бууж урсах устай газар; *голын хүрхрээ.*

ХҮРХРЭЭТҮҮЛЭХ хүрхрээтэхийн үйлдүүлэх хэв.

ХҮРХРЭЭТЭХ хүрхрээтэй болох.

ХҮРЦ а м ь т а н далайд орших, цагаан өөхтэй нэгэн зүйл загас.

ХҮРЦЭХ бух мөргөлдөхийг завдаж хялайн хэрж зогсох; *бух хүрцэх.*

ХҮРЧИГНҮҮЛЭХ хүрчигнэхийн үйлдүүлэх хэв.

ХҮРЧИГНЭХ өтгөн ихээхэн дууны үргэлжлэн дуугарах, хүржигнэх; *аянгын дуу үргэлжлэн хүрчигнэх.*

ХҮРЭВТЭР баахан хүрэн өнгө, хүрэндүү.

ХҮРЭГНЭХ хүрэн болох.

ХҮРЭЛ гуулинд тугалга хольж найруулан хийсэн хиймэл төмөрлөгийн нэр; **хүрэл зэвсгийн үе** (эртний судлалын нэгэн үе бөгөөд энэ үед хөдөлмөрийн багаж зэвсэг, чимэглэл зэрэг зүйлийг хүрлээр хийж байжээ).

ХҮРЭЛЦҮҮЛЭХ хүрэлцэхийн үйлдүүлэх хэв.

ХҮРЭЛЦЭХ 1. хүрч гүйцэлдэх; *болзоонд хүрэлцэх; элбэг хүрэлцэх хөрөнгө; идэж хүрэлцэх хүнс;* 2. шүргэх, хүрэх, уулзах; *хоёр юм завсраа уулзаж хүрэлцэх; гар хүрэлцэх ойр хэмжээ;* 3. ухаан мэдрэлд багтах, туулах; *бодол хүрэлцэх хялбар утга; ухаан хүрэлцэхэд бэрх утгатай ном.*

ХҮРЭЛЦЭХГҮЙ хүрч гүйцэлдэхгүй, хүрэлцээгүй.

ХҮРЭЛЦЭЭГҮЙ хүрэлцээ муутай, хүрэлцэхэд бэрхтэй, дутмаг.

ХҮРЭЛЦЭЭТЭЙ хүрэлцээ сайтай, элбэг хангалуун.

ХҮРЭМ I дээлийн гадуур давхацлан өмсөх охорхон хувцас, дүр төлөв олон зүйл; *онондой хүрэм; богино хүрэм;* **морин хүрэм** (уртхан хүрэм).

ХҮРЭМ (ЭН) II 1. уулын орой ба цэжин биеэр сул чулуу бүрхсэн газар; 2. галт уулын дэлбэрэлтээс бүрэлдэж бий болсон хөнгөн чулуу.

ХҮРЭН улаанд хар хольцож баахан харавтар болсон нэгэн зүйл өнгө зүсэм; *хүрэн өнгийн эд юм; хүрэн зүсмийн мал;* **хүрэн улаан** (улаан өнгө дийлэнх хүрэн); **хүрэн зос** (газраас гарах улаан хүрэн өнгөтэй шороон будаг); **хүрэн мөөг** у р г а м а л (иш нарийн бөгөөд хүрэн шүхэртэй нэгэн зүйл иддэг мөөг).

ХҮРЭНДҮҮ хүрэвтэр өнгө, нилээд хүрэн.

ХҮРЭНДҮҮЛЭХ хүрэндэхийн үйлдүүлэх хэв.

ХҮРЭНДЭХ хэтэрхий хүрэн болох.

ХҮРЭНТҮҮЛЭХ хүрэнтэхийн үйлдүүлэх хэв.

ХҮРЭНТЭХ хүрэн өнгөтэй харагдах.

ХҮРЭНШИХ хүрэн шинжтэй болох; *өвсний толгой хүрэншиж байна.*

ХҮРЭХ 1. хүрэлцэх, тулах; *зорьсон газар хүрэх; гар бие хүрэх; хэл мэдээ хүрэх; дуу хүрэх газар; санасандаа хүрэх; хэмжээнд хүрэх;* **ам хүрэх** (амсах; *идээнд ам хүрэх);* **хушуу хүрэх** (үнэрлэж үнсэх): **гар хүрэх** (а. бага сага зодох; б. ажилд бага зэрэг оролцох); **үгэндээ хүрэх** (хэлснээ биелүүлэх); **насанд хүрэх** (арван найман насанд хүрэх, эрийн цээнд хүрэх, сонгох сонгогдох насанд хүрэх); 2. хэрэглэгдэхүүний гүйцэх хэм; *идэж хүрэх хүнс; хэрэглэж хүрэх хөрөнгө; дээл хүрэх даавуу;* **зүрхэнд хүрэх** (хурц нүмжигтэй зүйлд шандуурах; *өөх идээд зүрхэнд хүрч байна);* 3. очих, хүрэлцэх; *гэрт хүрэх; хотод хүрэх; дэлгүүрт хүрэх; танайхыг хүрэх гэж байв;* 4. өрнөх, төрөх; *үүр хүрэх; нойр хүрэх; өвчин хүрэх;* **дур хүрэх** (дурлах, дур хөдлөх); **хорхой хүрэх** (ямар нэгэн юманд шунаж дурлах); **гэжиг хүрэх** (гэжиг хөдлөх): **халаг хүрэх** (тэсч ядах сэтгэл төрөх); **хор хүрэх** (а. хор хөнөөл болох; б. хор хөдлөх); **дургүй хүрэх** (сэтгэлд тааламжгүй санагдах); 5. өвдөх, учрах, тохиолдох; **өвчин хүрэх** (өвчин тусах, өвчин халдах); **ханиад хүрэх** (ханиад өвчин тусах): **аминд хүрэх** (үхэх аюул тохиолдох, учрах); 6. тулгарах, завдах; *шээс хүрэх.*

ХҮРЭХГҮЙ тоо хэмжээнд хүрэх хүрэлцэх боломжгүй, дутуу дулим; *арав хүрэхгүй хонь; алд хүрэхгүй дээс; идэж хүрэхгүй хоол; дээл хүрэхгүй даавуу.*

ХҮРЭЭ (Н) I 1. юмны гадуур хашаалж хороолж хийсэн юм; **хашаа хүрээ, хороо хүрээ** х о р ш.; *хүрээ хийх; шалны хүрээ;* 2. байран суурин газар; *нийслэл хүрээ; хот хүрээ; хийд хүрээ; хүрээ хөдөө;* 3. юмны гадуур захаар тойрсон зүйл; *зургийн хүрээ; тоононы хүрээ; сарны хүрээ;* 4. байрлан төвлөх газар байгууллага; *цэргийн хүрээ; бичиг шашдир зохиох хүрээ; зочид буух хүрээ; цэцгийн хүрээ;* 5. юмны гадуурхи зах ирмэг, амсар; *тогооны хүрээ; аяганы хүрээ; шархны хүрээ;* **мөөгний хүрээ** (мөөг ургах голдуу тал дугараг хэлбэртэй тод ногоон харагдах газар; *уулын бэлд байгаа мөөгний хүрээнээс цагаан мөөг түүв).*

ХҮРЭЭ II а м ь т а н толгой ба хамар хүртэл битүү хайрстай нэг зүйл загас.

ХҮРЭЭЛҮҮЛЭХ 1. хүрээлэхийн үйлдүүлэх хэв; 2. хүрээлэгдэх.

ХҮРЭЭЛЭГДЭХ хүрээлэхийн үйлдэгдэх хэв.

ХҮРЭЭЛЭН 1. шинжлэх ухааны аливаа салбар ухааныг судлах эрдэм шинжилгээний байгууллага; *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэн;* 2. цэцэг ногоо, жимс мод цэцэрлэг харьяалсан хороо, газар; *цэцгийн хүрээлэн; цэнгэлдэх хүрээлэн.*

ХҮРЭЭЛЭНЧ цэцгийн хүрээлэн сахигч хүн.

ХҮРЭЭЛЭХ 1. юманд хүрээ татах, хийх; *зураг хүрээлэх; бичгийн ташаа бүрүүг хүрээлэх;* 2. юмыг тойрч байх ба тойрсон чанартай түшиг тулгуур болох; *удирдлагаа хүрээлэх; тойрон хүрээлэх.*

ХҮРЭЭШИХ хүрээ суурин газарт идээших.

ХҮСЛЭГ хүсэл, мөрөөдөл.

ХҮСЛЭН хүсэл болсон, мөрөөдөл болсон нь; *бид чинь кино үзэхийн хүслэн болоод байна!*

ХҮСНЭГ I мэдээ тоо зэргийг жагсааж бичихэд зориулсан шугам, зураас, хүснэгт; *хүснэг бөглөх.*

ХҮСНЭГ II: **хүснэг цэцэг у р г а м а л** намуу цэцгийн төрлийн нэг зүйл цэцэг.

ХҮСНЭГДЭХ хүснэг татах.

ХҮСНЭГЛЭХ хүснэгтэй болох, хүснэгт оруулах.

ХҮСНЭГТ хүснэгтэй болгосон юм.

ХҮСҮҮЛЭХ хүсэхэд хүргүүлэх.

ХҮСҮҮШТЭЙ хүсмээр, дурламаар; *хүсүүштэй зүйл.*

ХҮСЭЛ ямар нэг юманд дурших бахдах мэтээр эрмэлзэх мөрөөдөх сэтгэл; **хүсэл эрмэлзлэл, хүсэл мөрөөдөл, хүсэл дурлал** х о р ш.; *сурах хүсэл; идэх хүсэл; ажиллах хүсэл; авах хүсэл; хөдөө явах хүсэлтэй; нийгмийн хүсэл сонирхлыг дагуулах.*

ХҮСЭЛГҮЙ дурших зүйлгүй, дур саналгүй.

ХҮСЭЛТ хүсэх үйлийн нэр, хүссэн зүйл **эрэлт хүсэлт** х о р ш.; *санал хүсэлтээ илэрхийлэв.*

ХҮСЭЛТЭЙ 1. дурламаар, хүсмээр сайхан, хүсүүштэй; *сайн явдлыг хүсэлтэй, муу явдлыг тэвчилтэй;* 2. хүсэл дурлал ихтэй, хүсэл бүхий; *би мал маллах хүсэлтэй.*

ХҮСЭМГҮЙ хүсмээр зүйл биш, хүсэхгүй, дурламгүй.

ХҮСЭХ 1. бахдан дурших сэтгэл **төрөх**, эрмэлзэх, горилох; *эрдмийг хүсэх; эхийгээ хүсэх; идэхийг хүсэх; эрхлэхийг хүсэх;* 2. гуйх; *би сургуульд орохыг танаас хүсч байна; хүссэн зүйлийг олгоё.*

ХҮҮ I 1. хүүхэд, эрэгтэй хүүхэд; *миний хүү; сая нэг хүү нэмэв; одоо хүү хүүхэн хоёртой болов;* 2. янаг хайртай хүн; *амраг хүү; эвий, хонгор хүү минь.*

ХҮҮ II 1. эд таваар хадгалах газар; **хүү сан, сан хүү** х о р ш.; 2. зээлдүүлсэн мөнгөний дээр өсч нэмэгдэх хувь; *зээлийн хүү; үржил хүү; хүүтэй мөнгө.*

ХҮҮ III хүч нэмэгдүүлэх үг; *хүү татах; хүү цохих; хүү гишгэх.*

ХҮҮГЛЭХ хүлхэх.

ХҮҮГҮЙ I 1. хүүхэдгүй; *тэднийх огт хүүгүй айл билээ;* 2. эрэгтэй хүүхэдгүй; *хүүгүй, ганцхан охинтой юм.*

ХҮҮГҮЙ II 1. **хуримталсан** хадгалсан сан хөрөнгөгүй; *сан хүүгүй;* 2. үржиж өсөн нэмэгдэх хувь хүүгүй; *хүүгүй мөнгө.*

ХҮҮГҮҮРДЭХ авд зогсохгүй дэмий ярих; *дэмий хүүгүүрдэж суух ямар ч ашиггүй.*

ХҮҮГЭХ I илүү үгтэй, яриад зогсдоггүй, салдаггүй, үргэлжлэн хэлэлцэх.

ХҮҮГЭХ II хуурай салхины хуугинан сүүгж салхилах; *салхи хүүгэх; хүүгэтэл салхилах.*

ХҮҮДИЙ юм хум агуулах уут сав; **хүүдий шуудай** х о р ш..

ХҮҮДИЙЛЭХ 1. хүүдий савд юм хум хийх, агуулах; *будаа хүүдийлэх; тариа хүүдийлэх;* 2. юмны завсар булан зэрэгт юм орж хурж тогтох; *дээлийн хормойд шороо хүүдийлэх; гуталд ус хүүдийлэх.*

ХҮҮЕ дуудахад хэрэглэх аялга; *хүүе, Дорж оо! хүүе, хүүе, хэн бэ?*

ХҮҮЛҮҮЛЭХ хүүлэхийн үйлдүүлэх хэв.

ХҮҮЛЭГЧ: мөнгө хүүлэгч бусдад мөнгө юмыг хувь хүүтэй өгч завшин мөлжих этгээд.

ХҮҮЛЭХ I мөнгө юмыг бусдад хувь хүүтэй зээлүүлэх; *мөнгө хүүлэх; мал хүүлэх.*

ХҮҮЛЭХ II хүүрэхэд хүрүүлэх, хүүрүүлэх.

ХҮҮР амьтны үхдэл: **хүүр үхдэл** х о р ш.; *хүний хүүр; малын хүүр;* **хүүр нясгах, хүүр барих** (хүүрийг гараар барих); **хүүр оршуулах** (хүний хүүрийг газарт булах, гээх мэтээр тавих); **хүүрийн газар** (хүүр оршуулах газар); **хүүрийн оршил** (хүүр оршуулсан газар); **хүүрийн булш** (үхдэл оршуулах нүх, түүн дээр бий шороо, дурсгал хөшөө зэрэг); **хүүрийн тавиур** (үхдэлийн авсны тавиур); **хүүр хайлах** (хүүр шатаах, чандар болгох).

ХҮҮРЗГЭНЭ тагтааны өөр нэр.

ХҮҮРҮҮЛЭХ хүүрэхийн үйлдүүлэх хэв.

ХҮҮРШИХ эд юмны удах буюу гал наранд ээгдэх зэргээр үжирч муудах, гутах, хэврэгших.

ХҮҮРШҮҮЛЭХ хүүршихийн үйлдүүлэх хэв.

ХҮҮРЧИН ясчин.

ХҮҮРЭГ I 1. ааруул ээзгий, амуу тариа зэрэг идээний идэх зажлахад хэмхрэх даагдахдаа хэврэг хялбары нь; 2. шар бударганын идээ, түүгээр хийсэн гурил; *хүүргийн гурил.*

ХҮҮРЭГ II цан; **цан хүүрэг** х о р ш..

ХҮҮРЭГШИХ хэврэгших, хүүрших.

ХҮҮРЭГШҮҮЛЭХ хүүрэгшихийн үйлдүүлэх хэв.

ХҮҮРЭХ юм хумны хялбар түргэн хэмхрэх, урагдах; *хүүрэх хялбар ааруул ээзгийг хэмхлэн зажлахад дөхөмтэй; хэврэг муу эд бөс хүүрэх тамтрах нь түргэн.*

ХҮҮСЭР хүүхэдгүй; *хүүсэр эм; хээрийн гөрөвсөнд эзэнгүй, хүүсэр эмд хүүхэдгүй* с э ц э н.

ХҮҮХДЭРХҮҮ 1. хүүхэд маягийн зан байдалтай; 2. хүүхэд багачуудын ихээр зангүй, хөөрхөн ааштай.

ХҮҮХЛЭГ 1. хүүхэмсэг; 2. нас их болсон атлаа бяцхан хүүхний байдал гаргах.

ХҮҮХРЭХ уухирах, их дуугаар бархирах; *хүүхрэн хашгирах.*

ХҮҮХЭД бага насны **хөвгүүд** охид; *нялх хүүхэд; хөхүүл хүүхэд; эрэгтэй хүүхэд; эмэгтэй хүүхэд; хүүхэд бужигналдан наадаж байв; сургуулийн насны хүүхэд;* **хүүхэд олох** (жирэмсэн болох); **хүүхэд дурсах, хүүхэд дурьдах** (хүүхэд төрөх гэж өвдөх, нярайлах гэж өвдөх); **хүүхэд хөдлөх, хүүхэд амилах** (хэвэл дахь хүүхэд амилж хөдөлгөөн орох); **хүүхэд гажих, хүүхэд эвгүйдэх** (хэвэл дэх хүүхэд байрнаасаа хөдөлж эвгүйцэх): **хүүхэд саатуулах** (хүүхэд зугаацуулах; *хүүхэд саатуулах газар);* **хүүхдийн цэцэрлэг** (сургуулийн

өмнөх насны хүүхдийг хүмүүжүүлэх газар); **хүүхэд бойжуулах** (хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх); **хүүхэд эх барих** (хүүхдийг төрмөгц хүйгий нь огтолж гардан авах); **хүүхэд өргөж авах, хүүхэд үрчлэх** (бусдын хүүхдийг өөрийн үр болгож авах); **хүүхэд авах** (а. хүүхэд өргөж авах: б. хүүхэд харж харгалзах); **хүүхэд зан** (хүүхдийн зан байдалтай).

ХҮҮХЭДГҮЙ үргүй, хүүхэд төрөөгүй; *хүүхэдгүй айл.*

ХҮҮХЭЛДИЙ хүүхдийн тоглоомонд зориулан үйлдсэн хүн амьтны дүрс); **хүүхэлдийн театр** (хүүхэлдийн жүжиг гаргах театр).

ХҮҮХЭМСҮҮ бага насны охидын хүүхэн хүний зан байдалтайгий нь, хүүхэмсэг.

ХҮҮХЭМСЭГ хүүхэмсүү.

ХҮҮХЭМСЭХ 1. хүүхэмсүү зан гаргах; 2. эмэгтэй хүний тусгайлан хүнд дуршаагдах таалагдах байдлаар аашлах.

ХҮҮХЭН 1. биед төрсөн охин; 2. бие гүйцсэн боловч эрд гараагүй эмэгтэй; *хүүхэн хүн;* **хүүхэн ул** (гутал шаврын улны дээр давхацсан нимгэн ул); **хүүхэн нуруу** (байшин асрын хос нурууны доод нарийн нуруу); **хүүхэн хэл** (хүн амьтны ам хамрын сувний үүлзар, нарийн тус дээрх ояцхан шовгор мах); **хүүхэн цэцгий, хүүхэн хараа** (нүдний гал цэцгий); **хүүхэн сарьс** (гутлын ул зулаг хоёрын завсар хавчуулан оёсон илэг сарьс); **хүүхэн дурдах** (нярайлахыг завдаж өвдөх).

ХҮҮХЭНЦЭР хүүхэн мэт ааш байдалтай.

ХҮҮХЭР хоосон цуудамч хүн, уульхай хүн.

ХҮҮХЭРХҮҮ хүүхэмсэг, хүүхэн байдалтай.

ХҮҮХЭЭЛЭХ хүүхээн гэж дуудах.

ХҮҮХЭЭН бага насны хөвгүүд охидыг тааламжлан дуудах үг; *хүүе, хүүхээн чи наашш ир!*

ХҮҮЧИХ байн байн хүүлэх.

ХҮҮЧҮҮЛЭХ хүүчихийн үйлдүүлэх хэв.

ХҮҮШ 1. нарны ээлт огт тусахгүй буюу эсэхүл эрт оройн нар тусахгүй маш сүүдэрлэсэн газар; 2. хад уулын ар ёроол буюу ар хажуугийн ам мэтийн уул хадны сүүдэр тохиолдох газар.

ХҮҮШДЭХ хэтэрхий хүүш болох.

ХҮҮШЛЭХ 1. махыг нар тусахгүй газар өлгөж өвүүлэх; *мах хүүшлэх;* 2. өглөө үдэш нар ууланд халхлагдан сүүдэрлэх; *нар хүүшлэх; хүрэн толгойн сүүдэр, хөндийгөө дагаад хүүшилнэ дээ хөө* (ардын дуу).

ХҮХТЭНЭХ хайртайн учир амыг хамхисаар дуугарах нэгэн зүйл аялга; *хүн хүхтэнэх; мал үүрсэж хүхтэнэх.*

ХҮХЭР химийн махбод болох шар өнгөтэй шатах бодис; эмнэлэг, техникт хэрэглэнэ; *хүхрийн хүчил.*

ХҮХЭРЛЭГ хүхэр бүхий; *хүхэрлэг натри.*

ХҮХЭРТЭЙ хүхэр бүхий, хүхэрлэг.

ХҮХЭЭ I хүн амьтны хоолойн хөндий; **зуухны хүхээ** (зуух яндан хоёрын хоорондох хөндий залгаа); **бууны хүхээ** (бууны сум агуулах хоолой зай): **хүхээ хайрцаг** (бууны сум агуулах хайрцаг).

ХҮХЭЭ (Н) II хүүхээн.

ХҮХЭЭЛҮҮЛЭХ хүхээлэхийн үйлдүүлэх хэв.

ХҮХЭЭЛЭХ хүхээ гэж дуудах.

ХҮЧ (ИН) I 1. аливаа юмны хөдлөх, үйлдэх чадал, ид, тэнхээ тамир; **ид хүч, хүч чадал** х о р ш.; **бүх хүч, хамаг хүч** (байдаг л чадал); **хүч хүрэх** (давж дийлэх); **хүч хүрэхгүй** (дийлэхгүй, чадал чадвараас давуу); **хүчээ хураах** (хүч чадвараа хайрлах, нөөх); **хүч сорих, хүч тэнсэх** (илүү дорыг шалгаруулан үзэх): **хүч авах** (а. чадал чинээ нэмэгдэх; б. бүл хүч нэмэх); **хүч орох** (а. чадал тэнхээ нэмэгдэх; б. тарга хүч нэмэгдэх; в. их хүч, их хөдөлмөр орох); **тулах хүч** (түшиж тулгуурлах зүйл): **хүч тэмцэх** (байдаг чадал чадвараа хэрэглэх); **хүч хэрэглэх** (хүч чадвар түрэх); **хүч нийлэх** (а. хүч хамтрах, эвсэх; б. эе эв, дэм дүй харилцан нийцэх); **хүч хавсрах, хүчээ хавсрах** (эвсэж хамтран ажиллах); **хүчийг ашиглах** (ажил хөдөлмөрт зүтгүүлж ашиглах: *усны хүчийг ашиглах);* **хүч түрэх** (чадал чадвараараа эзэрхэх); **хүч тасрах** (чадал тамир алдрах, барагдах); **хүч барагдах** (хүч чадвар мохох, доройтох); **хүч мөхөс** (а. хүч дутуу, хүч дорой; б. хүн бүл цөөн дутмаг): **хүч алдах** (а. чадал муудах, ядарч доройтох; б. тарга буурах, турах); **хүч буурах** (а. тамир тэнхээ доройтох; б. тарга нь муудах, нимгэрэх); **хүчээ үзэх** (чадал тэнхээгээ тэнсэх); **хүчий нь үзэх** (а. чадал тэнхээгий нь үзэх: б. тарган туранхайгий нь үзэх); **хүчээ дайчлах** (байдаг чадал чадвараа гаргах); **хүч дийлэх** (чадал чадвараар эзэрхэх, давамгайлах); **хүч гаргах,**

хүчээ гаргах (хүч чадвараа үл хэйрлах); **хүч мэдэх** (хүч чадал, чадвар чинээний хирээр болох); **хүчээр дайрах** (чадлаараа дайрах); **зүтгэх хүчин** (зөөх тээх үйл ажилд хэрэглэгдэх хөсөг, ачлага); **түлхэх хүч** (алив юмны өөрөөсөө түлхэж холдуулах чадал); **татах хүч** (алив юмны өөртөө татаж ойртуулах чадал); **хүчин зүйл** (алив үйл явдал, үзэгдлийн хөдөлгөх хүчин, шалтгаан); 2. цэргийн ид, чадал, сүр; **сүр хүчин** х о р ш.; **зэвсэгт хүч** (хуурай замын ба агаар, тэнгэсийн цэргийн хүчин); **гол хүчин** (их цэрэг); **туслах хүчин** (туслах цэрэг; *дайсантай тулалдан сум дуусч байхад манай туслах хүчин ирэв);* 3. энэрэл, хайр, тус, ач, ачаар; *хайрт нам зассийнхаа хүчээр хүмүжив; бусдын хүчинд шүтэж явдаг; ахынхаа хүчинд сургууль төгсөв; илүү цаг суусны хүчээр энэ ажлыг дуусгав; эрт боссоны хүчээр;* **ач хүч** (энэрэл, хайр, халамж); **түших хүч** (найдаж итгэх, дулдуйдах зүйл); **эмийн хүч** (эмийн ач тус); **эрдмийн хүч** (эрдмийн ач чадал); 4. хөдөлмөр; **хүч хөдөлмөр, хүч хөлс, ацаг хүч** х о р ш.: **хүчин үнэлэх** (биеийн хөдөлмөр хийж амьдрах); **биеийн хүч** (биеийн хөдөлмөр); 5. амьтны тарга; **хүч тарга** х о р ш.; *хүч тарган морь; малын хүч тарга сайн;* **хүч нэмэх** (а. тарга хүч нэмэгдэх; б. хүн бүл хүчин сэлбэх); **хүчээ тогтоох, хүчээ хадгалах** (а. тарга тэвээргээ үл алдах: б. чадал тэнхээгээ үл алдах); 6. идэвх, идэвхтэй үйл ажиллагаа; **хүчин төгөлдөр** (идэвх гүйцэд); **хүчин төгөлдөр болох** (идэвх гүйцэд болох); **ажиллах хүч** (ажиллах хүн); 7. хүн, ажилчин, ажилтан: **боловсон хүчин** (засаг захиргаа, нам олон нийт, үйлдвэр хөдөө аж ахуй, соёл шинжлэх ухааны үйл хэрэгт ажиллах ажилтан нар); **боловсон хүчний хэлтэс** (боловсон хүчний хэрэг эрхлэх хэлтэс); **боловсон хүчний эрхлэгч** (боловсон хүчний хэрэг эрхлэх хэлтсийн эрхлэгч); **хүчний хүргэн** (эхнэрийн гэрт биеэр ирж ханьцсан эр); **хүчний хүн** (хүчээ үнэлсэн хүн); ☆ **үйлдвэрлэх хүчин** (үйлдвэрлэлийн багаж, ажиллах хүн); **морины хүч** (далан таван килограмм метр секунд буюу 0,736 киловаттай тэнцэх чадал хэмжих нэгж); **хүчин нүдэн** (тавин оронтой тоо); **их хүчин нүдэн** (арван хүчин нүдэнтэй тэнцүү буюу тавин нэгэн оронтой тоо); **хүчний хэрэг, хүчингийн хэрэг** (эмэгтэйчүүдтэй хүчирхэн явалдсан хэрэг).

ХҮЧ II исгэлэн; **хүч орох** (айраг тараг зэргийн идээний исч хахан амттай болох).

ХҮЧ III бууны замаг мэтийн оньст зэвсэг **хэрэглэлийн дэлдэх** тийрүүлэхээр тохируулж **хийсэн** хэрэглэл.

ХҮЧГҮЙ I 1. чадал тэнхээ муутай; 2. хүн бүл мөхөс; 3. тарга тэвээрэг муутай; 4. ид чадал муутай; 5. түшиг тулгуур муутай; *дургүйд хүчгүй* з ү й р.

ХҮЧГҮЙ II исгэлэн хүчтэй биш; *хүчгүй тараг.*

ХҮЧГЭЛЖ у р г а м а л алтан зүржтэй адилхан бөгөөд бяцхан, жимс маш няг, амт маш хүчтэй, уул хээр ургана.

ХҮЧДЭЛ вольтоор илэрхийлэгдэх цахилгаан тогийн хүчний хэмжээ; *их хүчдэлтэй тог; өндөр хүчдэл.*

ХҮЧДЭХ хүч ихэд гаргах.

ХҮЧИЛ лакмус гэдэг хөх өнгийн цаасыг хийвэл улаан болгодог химийн нэгдэл, амт исгэлэн; *азотын хүчил; хүхрийн хүчил.*

ХҮЧИЛДЭР I 1. исгэлэн амттай; 2. хүчил бүхий.

ХҮЧИЛДЭР II у р г а м а л янз хар гүйлстэй адил бөгөөд том, амт маш хүчтэй нэгэн зүйл жимс.

ХҮЧИЛМЭГ у р г а м а л янз алимтай адил бөгөөд баахан бяцхан, хальсыг эмэнд хэрэглэдэг нэг зүйл жимс.

ХҮЧИМДЭХ хүчлэх, хүч чадал гаргах.

ХҮЧИНГИ у р г а м а л хээр ойт хээрийн бүсэнд хайргадуу, элсэрхэг хөрстэй газар ургадаг олон наст тэжээлийн буурцагт ургамал.

ХҮЧИНГҮЙ идэвх төгөлдөр биш; **хүчингүйд тооцох** (идэвх ажиллагаагүйд тооцох); **хүчингүй болох** (идэвхтэй үйл ажиллагаагүй болох).

ХҮЧИНТЭЙ идэвх төгөлдөр: **хүчинтэй болох** (идэвх төгөлдөр болох); **хүчинтэй байх** (идэвх гүйцэд байх); **хүчинтэйд тооцох** (идэвхтэй хэвээр байгаад тооцох).

ХҮЧИР үйл ажлын түбэг бэрхшээл ихтэйгий нь; **хүнд хүчир** х о р ш.; *хүчир ажил; хүчир өвчин; хүчир хэрэг.*

ХҮЧИРДЭХ хүчир бэрх нь хэтийдэх; *өвчин эмгэг хүнддэж хүчирдэх; үйл ажил хатуудан хүчирдэх.*

ХҮЧИРЛЭХ их хүч гаргах.

ХҮЧИРХИЙЛҮҮЛЭХ хүчирхийлэхийн үйлдүүлэх хэв.

ХҮЧИРХИЙЛЭХ хүчирхэх; *хүчирхийлэн дарлах; хүчирхийлэх байдал илэрч байна.*

ХҮЧИРХҮҮЛЭХ 1. хүчирхэхийн үйлдүүлэх хэв; 2. хүчирхэгдэх.

ХҮЧИРХЭГ хүч чадал их, сүр хүч их, дээрэлхэг түрэмгий; *эдийн засгаар хүчирхэг; эр цэргээр хүчирхэг; хүчирхэг улс; хүчирхэг нь буурайгаа дарлах ёс байхгүй.*

ХҮЧИРХЭГЛЭХ хүчирхэг зан байдал гаргаж түрэмгийлэх.

ХҮЧИРХЭХ хүчирхэгдээ эрдэж бусдыг дарлах доромжлох, хүчээр түрэмгийлэх; *хүчирхэн дарлах; хүчирхэн булаах; хүчирхэн явалдах.*

ХҮЧИТ хүч чадал, тэнхээ бүхий; *хүчит араатан;* **хүчит бөх** (чадал тэнхээтэй бөх; *хүчит бөхийн барилдаан*).

ХҮЧЛҮҮЛЭХ хүчлэхийн үйлдүүлэх хэв.

ХҮЧЛЭХ хүч оруулах, хүч гаргах.

ХҮЧТЭЙ I 1. хүч чадал бүхий, чийрэг; *хүчтэй хүн; хүчтэй амьтан;* 2. хүн бүл сайтай; 3. тарга тэвээрэг сайтай; *хүчтэй тарган морь; хур хүчтэй мал;* 4. ид чадал ихтэй; **хүчтэй эм** (чанар чадал ихтэй, тус хор ихтэй эм); 5. түшиг тулгуур сайтай.

ХҮЧТЭЙ II исгэлэн хүч бүхий; *хүчтэй тараг; хүчтэй ааруул ;хүчтэй жимс;* **хүчтэй жүрж** у р г а м а л (бэрсүүт жүржийн нам, амт маш хүчтэй, хяруу унасан хойно сая боловсорно, есөн хэлтэстэй, модондоо сундуутай).

ХЭВ I хэлбэр, янз, байдал, маяг; **хэв янз, хэв байдал, хэв маяг, хэв хэлбэр** х о р ш . : *хэв сайтай морь; хөөрхөн хэвтэй гэр; хэв муутай данх; хэвий нь сайн олоорой; хэв нь тааламжгүй байна; бичгийн хэв;* **хэв маягий нь** тааруулах (янз маягий нь тааруулах); **хэв шинжий нь гаргах** (дүр байдлы нь гаргах).

ХЭВ II 1. хээ хэлбэр гаргах багаж; *цутгуурын хэв; боовны хэв; туйпууны хэв;* 2. ном зураг зэргийн бар; *номын хэв; зургийн хэв; хорголжин хэв; тугалган хэв; модон хэв; хэв сийлэх;* 3. ором ,мөр; *гарын хэв шавар дээр гарчээ; цасан дээр хөлийн хэв гарсан байв;* **хэвт боорцог** (хэвт дарж хийсэн боорцгийн зүйл).

ХЭВ III дадаж заншсан уламжлалт ёс журам; **хэв ёс** х о р ш . ; хэв хууль (газар орны суртал, хүн ардын сэтгэлэг заншилд дадаж тогтсон ёс); **хэв суртал** (олон нийтийн нэгэнт дадаж заншсан ёс суртал); **хэв заншил** (нэгэнт хэвшсэн зуршил); **нийтийн хэв журам** (нийтийн дагаж шийтгүүлбэл зохих журам ёс).

ХЭВ IV зүй тухайг харгалзан төв шудрагыг барьж явах нь: **хэвийг сахих** (хүний ёс журмыг дагаж зөв зүйтэйгээр явах).

ХЭВ V энгийн, ерийн; *хэвийн хэрэг; хэвийн явдал; хэвийн мэнд сайн;* **хэвийн байдал** (байвал зохих ерийн байдал, хэмжээ); **хэвийн амьдрал** (ерийн амьдрал); **хэвээр** (хуучнаараа, урьдын, ёсоор; *хуучин хэвээрээ байна; байсан хэвээрээ байна*).

ХЭВ VI үйлийн эзэн уул үйлийг өөрөө үйлдэх буюу бусдаар үйлдүүлэх хийгээд бусадтай хамтран үйлдэх, бусадтай харилцан үйлдэлцэх, бусдын эрхэнд үйлдэгдэх, олуулаа үйлдэлцэх зэрэг санааг заах үйл үгийн хэлбэр; *үйл үгийн хэв; хэв байдлын дагавар; үйлдүүлэх хэв; үйлдэгдэх хэв.*

ХЭВ VII хүч нэмэгдүүлэх үг: ямагт огт, *хэв хэрэггүй зүйл.*

ХЭВ VIII: **хэв нэгхэн** хэвхэн.

ХЭВГИЙ хэлтгий, хазгай, хөнтөргөн; *хэвгий газар; хэвгий барьсан гэр.*

ХЭВГИЙДЭХ хэвэрхий хэвгий болох.

ХЭВГИЙЛЭХ хэвгий болгох.

ХЭВГИЙРЭХ хэвгий болох.

ХЭВГҮЙ хэв хэлбэр муутай, янз байдал муутай, эвгүй.

ХЭВДЭС хэвсэн юм нь; *малын хэвдэс.*

ХЭВИЙ зөвлөл.

ХЭВИЙДЭХ хэлэлцэх зөвлөлдөх; хэлэлцэх **хэвийдэх, зөвлөлдөх хэвийдэх** х о р ш . .

ХЭВИЙЛГЭХ 1. хэвийхийн үйлдүүлэх хэв, хэвгий болгох; *орон хэвийлгэх; газры нь хэвийлгэх;* 2. өнгөрөөх, өнгөрүүлэх; *би уд хэвийлгэж мордов; шөнө дунд хэвийлгэж унтав.*

ХЭВИЙЛЭХ зөвлөлдөх, хэлэлцэх; *олноороо хэлэлцэж хэвийлэх хэрэгтэй.*

ХЭВИЙХ 1. хазайх, хэлтийх, хэвгий болох, түвшингүй болох; *гэр чинь гэдрэгээ хэвийж орхижээ;* 2. хэмийн дундаас өнгөрсхийх; өдөр *дунд хэвийж байна; шөнө дунд хэвийж байв.*

ХЭВЛИЙ хэвэл.

ХЭВЛҮҮ ихжээр зан байдалтай.

ХЭВЛҮҮДЭХ хэтэрхий хэвлүүн болох.

ХЭВЛҮҮЛЭХ хэвлэхийн үйлдүүлэх хэв.

ХЭВЛҮҮН хэвийн жишээнээс хэтэрхий ихэмсэг ааль авиртай; **хэвлүүн хүүхэд** (бага хүүхдийн ихэжсэн томорсон хүний байдалтайгий нь); **хэвлүүн мал** (бага насны малын номхон идээшиг зантайгий нь).

ХЭВЛҮҮР хэв янз оруулдаг юм, хэлбүүр ч гэдэг; *гутлын хэвлүүр; малгайн хэвлүүр.*

ХЭВЛҮҮРДЭХ хэвлүүрээр хэлбэх, хэвлэх; *гутал хэвлүүрдэх.*

ХЭВЛҮҮРХЭХ хэвлүүн зан байдал гаргах.

ХЭВЛҮҮТЭХ хэвлүүн зан гаргах.

ХЭВЛҮҮХЭН арай хэвлүүн, нилээд хэвлүүн.

ХЭВЛЭГДЭХ хэвлэхийн үйлдэгдэх хэв; *ном хэвлэгдэх; зураг хэвлэгдэх; сэтгүүлд хэвлэгдэх.*

ХЭВЛЭГЧ хэвлэх үүрэг гүйцэтгэгч; *хэвлэгч машина; ном хэвлэгч.*

ХЭВЛЭЛ 1. хэвлэн гаргасан ном зохиол, бичиг, сонин сэтгүүл; *хэвлэл захиалга; сонин хэвлэл; ном хэвлэл; хэвлэлийн хуудас;* 2. хэвлэн гаргах ажлыг хариуцах газар; *цэргийн хэвлэл; хэвлэлийн газар.*

ХЭВЛЭХ юмыг хэвт дарж гаргах, дармаллах; *бичиг ном хэвлэх; боов чихэр хэвлэх; зураг хөрөг хэвлэх; хэвлэх үйлдвэр; хэвлэх газар.*

ХЭВНЭГ бороо цасанд өмсөх нөмрөх давхац хувцас, цув ч гэнэ; *өнгөрсөн бороонд эсгий хэвнэг нөмрөх* з ү й р.

ХЭВНЭГЛЭХ хэвнэг өмсөх.

ХЭВРЭГ бат бэхгүй, эвдрэх гэмтэх хялбар; *хэврэг эд; шил шаазангийн зүйл маш хэврэг; эд хэврэг, эзэн мөнх* (дээл мялаахад хэлэх үг).

ХЭВРЭГДҮҮЛЭХ хэврэгдэхийн үйлдүүлэх хэв.

ХЭВРЭГДЭХ хэврэгийн учир тохиромжгүй болох, хэтэрхий хэврэг болох.

ХЭВРЭГШИХ улмаар хэврэг болох.

ХЭВРЭГШҮҮЛЭХ хэврэгшихийн үйлдүүлэх хэв.

ХЭВРЭХ эрчтэй юмны эрч задарч тасран элэх, хэврэгших; *олс дээс хэврэх.*

ХЭВТҮҮЛ шөнийн манаач, эргүүл.

ХЭВТҮҮЛЭХ хэвтэхийн үйлдүүлэх хэв; *эмнэлэгт хэвтүүлэх.*

ХЭВТЭЙ хэлбэр сайтай; *сайхан хэвтэй гэр; хөөрхөн хэвтэй морь.*

ХЭВТЭЛЦЭХ хэвтэхийн үйлдэлцэх хэв.

ХЭВТЭР 1. хэвтдэг хэвтэш; *нохой хэвтэртээ хэвтэж байв; малын хэвтэр дулаан уу? хэвтэр сайтай хот;* 2. хэвтэж байгаа; *хэвтэр хүн; хэвтэр өвчтөн.*

ХЭВТЭХ 1. хүн амьтны хажуу хавиргаар буюу ар өвөөрөө хажуулан орших; *орон дээр хэвтэх; газар хэвтэх; хонь хотондоо хэвтэх; хэвтэж байсан мэргэнээс, хэсч явсан тэнэг дээр* з ү й р; 2. юмны газарт унаж байх; *хэдэр хүн хээр хэвтэх, хэдрэгний мод гадаа хэвтэх* з ү й р; 3. навтгар намхан болох; *гэр хэвтэх; майхан хэвтэх;* 4. хүндээр өвчлөх; *гэртээ хэвтэх; больницод хэвтэх; ханзлан хэвтэх.*

ХЭВТЭШ I амьтны хэвтэх газар; **хот хэвтэш** х о р ш.; *малын хэвтэш; үхрийн хэвтэш.*

ХЭВТЭШ II эм амьтны үр зулзага тогтох сав; **сав хэвтэш** х о р ш.; **хүүхэн хэвтэш** (чухам үр тогтох сав).

ХЭВТЭЭ 1. босоо биш, намхан; *хэвтээ гэр; хэвтээ майхан;* 2. хэвтэж байх юм; *хэвтээ хонь үргээхгүй; хэвтээгээрээ ургах; хэвтээ ургамал; хэвтээгээрээ ном уншиж байв;* **хэвтээ мэлхий** а м ь т а н (бие урт том, арьс зузаан, хайрс сархинаг шиг, дуу бүдүүн нэг зүйл мэлхий).

ХЭВХЭН хэвдээ, хэмдээ, аажимхан, аажуухан; *миний бие хэвхэн байна; би энэ өдөр ажилдаа хэвхэн очно.*

ХЭВЦГИЙ хэвцэг, ярдаг гажуу зантай; *хэвцгий хүүхэд; хэвцгий зан гаргах.*

ХЭВЦГИЙДЭХ хэтэрхий хэвцгий болох, хэвцэгдэх ч гэнэ.

ХЭВЦГИЙЛЭХ хэвцэглэх, хэвцгийн зан байдал гаргах.

ХЭВЦГИЙРХҮҮЛЭХ хэвцгийрхэхийн үйлдүүлэх хэв.

ХЭВЦГИРХЭХ хэвцгий зан ааш гаргах.

ХЭВЦГИЙРЭХ хэвцгий болох.

ХЭВЦГИЙТЭХ хэвцгийн зан царай гаргах.

ХЭВЦЭГ ярдаг, хэвцгий, хэдэр: **хэвцэг ярдаг, хэдэр хэвцэг** х о р ш..

ХЭВЦЭГДЭХ хэтэрхий хэвцэг болох.

ХЭВЦЭГЛЭХ хэвцэг зан гаргах, хэдэрлэх, ярдаглах, хэвцгийрхэх.

ХЭВЧ I этгээд маяг байдалтай.

ХЭВЧ (ИН) II хэв хийхдээ чадамгай.

ХЭВШИГДЭХ хэвшихийн үйлдэгдэх хэв.

ХЭВШИЛ хэвших үйлийн нэр; **дадал хэвшил, заншил хэвшил** х о р ш.; *амьдралын хэвшил; нийгмийн хэвшил.*

ХЭВШИХ I ямар нэгэн юманд дадаж идээших, хэвшил болох; **хэвших занших** х о р ш.; *тогтмол цагт идэж ууж хэвших; амарч хэвших; эрт босч, орой унтаж хэвших.*

ХЭВШИХ II юмыг түгших, цохих; *тариа будаа хэвших; сур арьс хэвших.*

ХЭВШМЭЛ тогтмол, тогтсон нь; *хуучнаасаа ахихгүй хэвшмэл байдалтай болсон байна;* **хэвшмэл хэллэг** (тухайн хэлэнд хэвшин хэрэглэгдэх болсон хэллэг).

ХЭВШНҮҮЛЭХ хэвшнэхийн үйлдүүлэх хэв.

ХЭВШНЭХ I хэвшиж занших, журамших; *нэгэнт хэвшнэсэн хэрэг.*

ХЭВШНЭХ II зөөлрөх, зүгшрэх, эвээ олох.

ХЭВШҮҮЛЭХ хэвшихийн үйлдүүлэх хэв.

ХЭВЭГ тариа будааны ааг хальс; *тарианы хэвэг; хэвгий нь арилгах.*

ХЭВЭГЛЭХ хэвгий нь арилгах, цайлгах; *тариа хэвэглэх; будаа хэвэглэх.*

ХЭВЭГЧ хэвдэг амьтад; *хонь ямаа үхэр тэмээ бол хэвэгч амьтад мөн.*

ХЭВЭЛ 1. амьтны аюулхайгаас доошхи газар; **гэдэс хэвэл** х о р ш.; 2. хүүхэд орших сав; *эхийн хэвэлд арван сар тээлгэж өсөв;* ☆ **хэвлээр явагчид** (сэ3р нуруутны нэгэн анги).

ХЭВЭХ 1. зарим амьтан идсэн өвс хоолоо гулгин гаргаж дахин зажлах; *хонь хэвэх; тэмээ хэвэх; үхэр хэвэх;* 2. идэх; **идэх хэвэх** х о р ш..

ХЭГД алтан өнгөөр хээ угалз тавьж хийсэн илэг нэхий.

ХЭГДГЭР 1. хүний сээр нуруу бөгтийж цээжин бие хагдгар болсон нь; 2. хүний ахиад байдалтайгий нь.

ХЭГЖИХ юмыг нарийвчлан нэгжиж эрэх; *завхсан мал эрж уул хад хэгжих; юм хум эрж авдар сав хэгжих.*

ХЭГЖҮҮН зөв бурууг ялгахгүй, хэдэр хөшүүн байдлаар зөрчих, гүжүүрхэх буюу үл тоомсорлох ааль авир: **хэдэр хэгжүүн, хөшүүн хэгжүүн** х о р ш..

ХЭГЖҮҮРХҮҮЛЭХ хэгжүүрхэхийн үйлдүүлэх хэв.

ХЭГЖҮҮРХЭХ хэгжүүн ааль аашгаргах; *чи мөчөөрхөн хэгжүүрхэх хэрэггүй .*

ХЭГЖҮҮРЭХ хэгжүүн зан ааш гаргах.

ХЭГЗ юмны өнгөн этгээд холтрох зулгарах нь; *хэгз татах; гарын арьсы нь хэгз татчихав.*

ХЭГЗГЭР хүний хэрдэг хэвцэг адайр ааш зангий нь буюу дээрэнгүй авир; **хэгжүүн хэгзгэр** х о р ш..

ХЭГЗИЙХ хэгзгэр зан байдал гаргах.

ХЭГЗЛҮҮЛЭХ хэгзлэхийн үйлдүүлэх хэв.

ХЭГЗЛЭХ хэгзрэхэд хүрүүлэх, хэгзрүүлэх.

ХЭГЗРҮҮЛЭХ хэгзрэхийн үйлдүүлэх хэв.

ХЭГЗРЭХ юмны өнгөн этгээд дарагдах шүргэгдэх мэтээр холтрох, зулгарах, шалбарах; *дээл хэгзрэх; ширээний будаг хэгзрэх; гарын арьс хэгзрэх.*

ХЭГЗЭЛЗЭХ хэгзгэр адайр зан байдал гаргах.

ХЭГСГЭР хүний зан ааль хир чинээнээс даваа дээрэнгүй буюу юманд тоомсоргүй.

ХЭГСИЙХ хэгсгэр зан байдал гаргах, хэгсэгнэх.

ХЭГСЭГНЭХ хэгсийх.

ХЭГСЭЛЗЭХ хэгсгэр зан гаргаж зөчрлах.

ХЭГЭХ 1. хэрчих, жижиглэх; *мах хэгэх; цаас хэгэх;* 2. зарим ирт юмны мохож юм даахгүй зажлах, хэвэх; *хайч хэгэх.*

ХЭГЭЭС тэрэгний хүрдний бул мөөрийг холбож тойрон хадсан ялуу; **ялуу хэгээс** х о р ш.; *тэрэгний хэгээс; дугуйны хэгээс суларчээ.*

ХЭГЭЭСЛЭХ хэгээс гаргах, хэгээс хийх.

ХЭД (ЭН) 1. юмны тоо хичнээн болохыг асуух төлөөний үг; **хэд хичнээн** х о р ш.; *та хэдэн настай вэ? хөдөө яваад хэд хоножбайна? танд хэд хэрэгтэй вэ? хэд дахин их байна; өнөөдөр хэдэн бэ? хэдэнд манайхаар ирэх вэ? сар бүрийн хэдэнд хуралтай байдаг билээ?*

хэдээр (хэд хичнээнээр; *хэдээр өгвөл болох вэ? хэдээр авах санаатай байна?*); 2. баахан цөөвтөр; *хэд хоногоос би ирнэ; хэдэн мал маллаж байна; манай хэдэн адуу үзэгдэнэ үү? энэ хэдэн хоног сайн чармайж ажиллавал төлөвлөгөөгөө биелүүлнэ шүү;* 3. гаруй; *хорин хэдэн сурагчид хичээллэж байна; арван хэдэн километр яваад нэг худаг дайралдана;* **хэд хэд** (хэдээд; *хүн тутам хэд хэд ногдох, та хоёулын нас хэд хэд хүрэв; хэд хэд дахин авав; хэд хэд вэ?*); **хэд хэдэн** (нилээд; *хэд хэдэн удаа; хэд хэдэн зэрэг; хэд хэдэн хувь*).

ХЭДГЭНЭ а м ь т а н зөгийн аймгийн нэгэн зүйл ялаа.

ХЭДДҮГЭЭР дэс тооны нэрийг асуух төлөөний үг; *хэддүгээр сард? хэддүгээр дэвтэр? хэддүгээр зэрэг?*

ХЭДИЙ 1. юмны тоо, хугацааг асуух төлөөний үг; *хэдий чинээн бэ? эндээс хэдий хол вэ? хэдийд ирэх вэ? хэдийд явах вэ?* 2. юмыг дурдан заагаад тайлбарлан эсэргүүцэхэд хэрэглэх үг; *давс хэдий шорвог ч болов идээнд найралтай, найр наадам хэдий цэнгэлтэй боловч ажилд садтай; хэдий тийм боловч бас учир бий;* **хэдийвээр** (юмыг заагаад тайлбарлан эсэргүүцэхэд хэрэглэх үг; *бид хэдийвээр тэтгэвэрт гарсан боловч ажил хийнэ; эм хэдийвээр гашуун боловч биенд сайн*); **хэдийгээр** (а. хэзээ; *та хэдийгээр явах вэ?* б. хэдийвээр; *манайхан хэдийгээр хүн цөөтэй боловч их ажил хийх гэж төлөвлөж байна*); **хэдийд** (ямар нэгэн үйл явдлын болсон буюу болох цагийг асуух төлөөний үг; *хэдийд ирэх юм бэ; галт тэрэг хэдийд хөдөлсөн бэ? хэдийд ч болно*); **хэдийн** (хэдийний; *хэдийн ирсэн хүн; хэдийн гүйцэтгэсэн ажил*); **хэдийний** (нэгэнт өнгөрсөн цагийг зааж хэлэлцэх үг; *тэр хүн хэдийний явсан; энэ ажил хэдийний эхэлжээ*).

ХЭДИЙЧИНЭЭН хэд хичнээн, юмны тоо хэмжээ багцаа төлөвийг асуух, төлөөний үг; *хэдийчинээн их бол төдийчнээн сайн байна.*

ХЭДМЭН лийр.

ХЭДРЭГ I арьс нэхий элдэхэд хэрэглэх зэвсэг, нэг талдаа хөрөөний ир мэт иртэй урт нарийн хавтгай мод буюу төмөр.

ХЭДРЭГ II: **хэдрэг оосор** хэтрээ; **хэдрэг од** з у р х а й (тэнгэрийн охин гэдэг одны өөр нэр).

ХЭДРЭГДҮҮЛЭХ хэдрэгдэхийн үйлдүүлэх хэв.

ХЭДРЭГДЭХ арьс нэхийг хэдрэгээр татаж харах, элдэх; *нэхий хэдрэгдэх.*

ХЭДРЭМ амьтны туурайн дотоод зөөлөн.

ХЭДРЭМТГИЙ хэдрэх зантай, дэмий хэсэх тэнүүчлэх зантай; *ажилгүй хүн айл хэдрэмтгий.*

ХЭДРЭХ 1. уулын жалга сархиаг ихтэй газраар хүн амьтны ташлан явах; *уул хэдрэх; хэдрээд яваарай;* 2. айл хунараар дэмий хэсүүчлэн тэнэх; *айл хэдрэх.*

ХЭДҮҮЛ 1. хам тооны асуух төлөөний үг; *чи хэдүүл яваа вэ? энэ ажлыг хэдүүл хийвэл гүйцэтгэж чадах вэ?* 2. цөөн тоотой юмыг багцаалан хэлэлцэхэд хэрэглэх үг; *бид хэдүүл хүч хүрэхгүй.*

ХЭДҮҮЛХЭН хэдүүл, цөөн.

ХЭДХЭН хэдэн, цөөхөн; *хэдхэн үг хэлье; хэдхэн үхэртэй айл; хэдхэн унаа бий; хэдхэн төгрөг аль; хэдхэн хоног явна.*

ХЭДЭНТ (ЭЭ) хэдэн удаа; *төмөр хэдэнт дэлдэж дохио өгөв.*

ХЭДЭР хүн амьтны зан ааль догшин хэвцэг; **хэдэр догшин, хэдэр хэрцгий** х о р ш..

ХЭДЭРЛЭХ хэдэр ярдаг зан байдал гарган аашлах; *нохой хэдэрлэх.*

ХЭДЭЭД тус бүр хэд; *дөчин тавыг арван тавд хуваахад хэдээд ногдох вэ? арван таван хүний хэдээд бол дөчин тав хүрэх вэ?*

ХЭЕДЭХ ургамал ба байшин барилгын нөг тийш салжийж хазайх.

ХЭЕЛЭХ юмны нэгэн этгээд тийш хэлбэрэн хазайж унах.

ХЭЕН 1. нэхмэл барааны хоёр үзүүрийн зах; **зах хэен** х о р ш.; 2. утас нийтгэхэд ширхэг бөөгнөрч бүдүүрсэн буюу тээг гарсныг нь; *утасны хэен; хэен суух.*

ХЭЕНТЭХ нийтгэсэн юманд хэен гарах; *утас хэентэх.*

ХЭЕЭ шагаа орхиход морин талаараа буусны нь; *хэеэ босох.*

ХЭЖИМ I сарлагийн хэвэлд ургасан урт үс, зарим газар савга ч гэнэ.

ХЭЖИМ II х у у ч и р с а н тохом.

ХЭЖИРМЭГ хэжүү, хэжүүр.

ХЭЖИХ хэжүү хэжирмэгтэй газраар явах; *уулыг хэжиж авирах.*

ХЭЖЛҮҮР хэжүү, хэжүүр.

ХЭЖҮҮ уул хавцгайн хажуу халил, ус мөрний хөвөөгийн хясаа мэтийн явах туулах бэрхтэй газар, зам; *хэжүү газар; хэжүү зам.*

ХЭЖҮҮР хэжүү

ХЭЗЭЭ ямар нэгэн үйл явдлын болсон буюу болох цагийг асуух төлөөний үг; *хэзээ ирэв? хэзээ явах вэ? хэзээ ч ийм; хэзээ ч магадгүй; хэзээ хэзээгүй ирэх болсон; чиний ачийг хэзээ ч мартахгүй; сананаас хэзээ гардаг бол, мэдэхгүй; хэзээ ямагт; хэзээгээс эхэлж ажил хийсэн хүн бэ?*

ХЭЗЭЭД насад, ямагт, үргэлжид; *хэзээд бодогдоно; хэзээд бэлхэн! хэзээд мартахгүй.*

ХЭЗЭЭНИЙ хэдийний өнгөрсөн хэмийг хэлэлцэхэд хэлэх үг; *хэзээний хэв тогтсон хэрэг; хэзээний хүрч иржээ; би түүнийг хэзээний сайн танина.*

ХЭЛ I амны хөндийд байдаг амт мэдрэх эрхтэн; *үхрийн хэл; хэлээ хазах; хэлэн дээр нь чихэр тавьж, шилэн дээр нь хутга тавих* з ү й р; **хүүхэн хэл** (тагнайн үгт унжсан жижиг мах); **хэл чулчрах** (үг хэлэхэд хэлний ажиллагаа буруудах, халтирах зэргээр бүрэн зөв хэлж чадахгүй болох); **хэл чулчиг** (үг хэлэхэд ямагт хэл нь чулчирч хазгай музгай хэлэх өгүүлэх хүн); **хэл халтирах** (үг хэлэхэд буруугаар хэлэх): **хэл бүдгэрэх** (хэлний аялгуу тодорхойгүй болж хувирах); **хэл орох** (үг хэлж чадахгүй байсан хүний хэлэлцэх болох); **хэлд орох** (нялх хүүхдийн анх үг хэлж сурах); **хэл ээдрэх** (хэлэхэд хэл будлих); **хэлний хусуур** (хэлний өнгөр налдаа мэтийг хусч арилгах хэрэгсэл, эвэр хулс төмөрлөгийн зэрэг зүйлээр хийнэ); **хэл хуур** (аман хуур, хулсан хуур).

ХЭЛ II 1. хүмүүсийн харилцааны хамгийн чухал хэрэглүүр; *Монгол хэл; Орос хэл; Хятад хэл;* **ярианы хэл** (ерийн ам яриандхүүрнэн хэлэлцэх хэл); **хар хэл** (ярианы хэл); **бичгийн хэл** (нийт ардын хэлийг бичигт оруулан тогтоож нормтой болгож боловсруулсан хэлбэр); **этгээд хэл** (цөөн бүлэг хүмүүсийн хоорондоо ойлголцох, нийт олны хэлнээс ангид үг яриа); **хэлний шинжлэл** (хүн төрөлхтний хэл, түүний түүхэн хөгжлийг судлах ухаан); **хэлний шинжлэлч** (хэлний шинжлэлд мэрэгжсэн хүн); **хэл нугарах** (хэл зүгширч түлбэрэлгүй ярьж сурах); **хэл зүгшрэх** (түлбэрэлгүй цэвэр сайхан ярих болох); **хэл зүгшрүүлэх үгс** (түгдрэлгүй хэлж сурахад зориулан зохиосон бүлэг үгс); **хэл мэдэхгүй** (а. хэлэнд ороогүй; б. хэл сураагүй; в. хэлсэн сургасан хэл үг хэрэгсэж авдаггүй); **харь хэл, гадаад хэл** (өөрийн үндэсний биш хэл); **үндэсний хэл** (өөрийн төрөлх хэл); **хар хэл ам** (муулж муутгасан чанартай үг яриа); **цагаан хэл ам** (магтаж сайшаасан чанартай үг яриа); **хэл сурах** (аливаа хэлийг мэдэх өгүүлэх болон төсөөлөх); **хэл мэдэх** (а. ямар нэгэн хэлээр өгүүлсэн хэлэлцсэн ерийн өгүүлэл яриаг ойлгох; *үндэсний хэлээ мэдэх; харь хэл мэдэх;* б. үг сургамжинд орох); 2. үг, өгүүлэл; **хэл яриа гаргах, үг хэл гаргах** (хэл ам удах); **хэл удах, хэл ам удах** (хэрүүл цуугиан үүсгэх, өдөх); **хэл ам болох, хэл ам хийх** (хэрүүл цуугиан хийх ба зарга тэмцэл болох).

ХЭЛ III сураг мэдээ; *нутгаас хэл ирэв; хэл сураг алга байна;* **хэл мэдээ** (аливаа бичиг захидал, хэл сураг мэтээр мэдэгдэх харилцах мэдээ): **хэл хүргэх** (үг мэдээг уламжлах дамжуулах зэргээр нэвтрүүлэх); **хэл явуулах, хэл хүргэх** (бусдад ямар нэгэн аргаар мэдээ явуулах; *харин хэл явуулна);* **хэл зөөх** (хоёрын хооронд үг уламжлах); **хэл залгах** (а. үг мэдээ хүргэх; б. үг нэвтрэх); **хэл барих** (а. хоёрын хооронд хэл мэдээ залгуулж холбоо барих; б. дайсны талаас амьдаар олзлон авах); **хэл авах** (хүний харилцан хоорондоо бичиг захиа нэвтрэлцэх буюу амаар мэдээ авалцах).

ХЭЛ IV хонх болон бүс, олом, тэлээний арлын дотоодод бий унжуурга цохиур, тээглүүр, **горхины хэл** (арал горхины тээг): **хонхны хэл** (хонхны дотоод дахь цохиур).

ХЭЛБИЙГҮҮ хэлбэрүү; *хэлбийгүү зан ааль-тай хүн; нэндүү хазгай хэлбийгүү газар.*

ХЭЛБИЙЛГЭХ хэлбийхийн үйлдүүлэх хэв, хэлбийхэд хүргүүлэх.

ХЭЛБИЙХ хэлбэрэх, хэлтийх, хазайж эчих; *нар үд өнгөрч хэлбийх; санаа хувирч хэлбийх; ширээ урагшаа хэлбийх.*

ХЭЛБҮҮ хэлтгий, ташуу, түвшингүй; *хэлбүү газар.*

ХЭЛБҮҮЛЭХ хэлбэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЛБҮҮР юмыг тэлэх хэлбэхэд тохируулж хийсэн зүйл, хэвлүүр; *гутлын хэлбүүр; малгайн хэлбүүр.*

ХЭЛБҮҮРДҮҮЛЭХ хэлбүүрдэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЛБҮҮРДЭХ хэлбүүрээр юмыг хэлбэн засах, хэвлүүрдэх.

ХЭЛБЭГНЭХ хэлбэгэр юмны хэлбэг хэлбэг хөдлөх, хазганах, догонцох.

ХЭЛБЭГЭР юмны нэг тийшээ хазайсны нь.

ХЭЛБЭГЭРДҮҮЛЭХ хэлбэгэрдэхийн үйлдүүлэх хэв, хэлбэгэр болгох.

ХЭЛБЭГЭРДЭХ хэтэрхий хэлбэгэр болох.

ХЭЛБЭЛЗҮҮЛЭХ хэлбэлзэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЛБЭЛЗЭЛ хэлбэлзэх үйлийн нэр; *хэлбэлзэл их; хэлбэлзэл бага; газар хөдлөлийн хэлбэлзэл.*

ХЭЛБЭЛЗЭХ 1. хүний тогтворгүй хэлбэрэлзэх; *хоёрын хооронд хэлбэлзэх;* 2. юмны хэлтэлзэн дайвалзаж хөдлөх; *салхинд онгоц хэлбэлзэх.*

ХЭЛБЭР дүр дүрс, үзэгдэх байдал төлөв; **хэлбэр дүр, хэлбэр дүрс, хэлбэр янз, хэлбэр төлөв** хорш.; *дөрвөлжин хэлбэртэй мод; дүгрэг хэлбэртэй чулуу; хэлбэр сайтай тэмээ; сайхан хэлбэртэй гэр;* **хэл зүйн хэлбэр** (хэл зүйн утга агуулга, хэл зүйн аргын нэгдэл).

ХЭЛБЭРДЭХ хэлбэрийг гол болгох, хэлбэрийг чухалчлан үзэх.

ХЭЛБЭРЖИХ хэлбэртэй болох, хэлбэрээ олох.

ХЭЛБЭРЖҮҮЛЭХ хэлбэржихийн үйлдүүлэх хэв.

ХЭЛБЭРҮҮ 1. хэлбийгүү, хүний ааль үзэл шудрага түвшингүй гажуу сөдгий; *хэлбэрүү санаа агуулж хорлох; хэлбэрүүгээр мушгин аваачих;* 2. хэлтгий, түвшин тэгш биш, хөнтөргөн; *хэлбэрүү газар.*

ХЭЛБЭРҮҮЛЭХ хэлбэрэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЛБЭРШГҮЙ хөдөлж хувиршгүй, бат нут; *хэлбэршгүй бат найрамдал; хэлбэршгүй чанар.*

ХЭЛБЭРШИЛ хэлбэрших үйлийн нэр; *нийгэм эдийн засгийн хэлбэршил; хэлбэршлээ олох.*

ХЭЛБЭРШИХ хэлбэр шинж орох, олох, хэвших.

ХЭЛБЭРЭЛ хэлбэрэх үйлийн нэр, нугалаа; *хэрэг явдлын хэлбэрэл; барууны хэлбэрэл; хэлбэрэлгүй бат хүн.*

ХЭЛБЭРЭЛЗЭХ хэлбэлзэх, гуйвалзах, дайвалзах.

ХЭЛБЭРЭЛТ хэлбэрсэн нь; *хэлбэрэлт их; хэлбэрэлт нь бага.*

ХЭЛБЭРЭЛТГҮЙ хэлбэрэхгүй, буцалт няцалтгүй, урвалт хөрвөлтгүй.

ХЭЛБЭРЭХ нэг этгээд тийш хэлтийх, хазайх, далжийх, урвах няцах, гуйвах дайвах.

ХЭЛБЭХ юмыг тэлж уужим их болгох, засамжлах; *гутал хэлбэх; малгай хэлбэх.*

ХЭЛГИЙ үг хэлж үл чадах буюу **хэл нь** чулчарч үг бүрэн хэлж үл чадах хүн; *хэлгий хүүхэд; хэлгий хэлэх;* **хэлгий сарнаа** ургамал (хээр ургадаг сарнаагийн төрлийн нэгэн зүйл ургамал, цэцэг улаан, иш навч цөм ногоон); **хэлгий цэцэг** ургамал (намаг, цэцэглэгт ургадаг ургамал, цэцэг нь сарвуу мэт салаалан ургана, цэцгийн үнэр анхилам сайхан); **хэлгий уураг** (тэмээ үхэр, бага малын төл төрсний дараагийн буцалгахад өттөрөн налдаарах сүү).

ХЭЛГИЙВТЭР баахан хэлгий, арай хэлгий.

ХЭЛГИЙДЭХ хэлгий болох.

ХЭЛГИЙЛЭХ I хүүхэд багачуудын эрхэлж хэлгий мэтээр ярих.

ХЭЛГИЙЛЭХ II хэтэрхий хэлгийрэх.

ХЭЛГИЙРЭХ сүүг буцалгахад өтгөрөн налдаарах буюу ээдмэгтэх; *уураг хэлгийрэх; сүү хэлгийрэх.*

ХЭЛГИЙТЭХ хэлгийлэн ярих.

ХЭЛГҮЙ 1. үг хэлж огт чаддаггүй; 2. сураг мэдээгүй.

ХЭЛГЭЛЗЭХ ярих хэлэхэд ихэд ээрэх, түгдчих.

ХЭЛЛЭХ өгүүлэлдэх.

ХЭЛМЭГДҮҮЛЭХ хэлмэгдэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЛМЭГДЭЛ хэлмэгдэх үйлийн нэр; *дайны хэлмэгдэл.*

ХЭЛМЭГДЭХ урэгдэх, чирэгдэх; *дайн дажны хөлд хэлмэгдэх.*

ХЭЛМЭРЧ аливаа хэлний үгийг өөр хэлэнд орчуулан хэлэх хүн.

ХЭЛМЭРЧЛҮҮЛЭХ хэлмэрчлэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЛМЭРЧЛЭХ өөр хэлний үг үгтыг орчуулан хэлж дамжуулан хэлэлцэх.

ХЭЛТГИЙ 1. хазгай, тэгш биш, түвшин биш; *хэлтгий толгой; хэлтгий ширээ; хэлтгий шанага; хэлтгий хуваах; хэлтгий ногдуулах; хэлтгий үзэх;* 2. тал, хагас; **хэлтгий сар** (заримдаг сар); **хэлтгий сүх** (тал сүх); **хэлтгий хэнгэрэг** (тал хэнгэрэг).

ХЭЛТГИЙВТЭР баахан хэлтгий, арай хэлтгий.

ХЭЛТГИЙДҮҮЛЭХ хэлтгийдэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЛТГИЙДЭХ 1. хэтэрхий хэлтгий болох; 2. юмыг хуваасан нь тэгшгүй илүү дутуу болох.

ХЭЛТГИЙЛЭХ хэлтгий болгох; *дандаа авсан эд юмыг нэг нь дангаар болгон хэлтгийлж авах; хэрэг заргыг нэг тийш болгохдоо хэлтгийлж шийтгэх.*

ХЭЛТИЙЛГЭХ хэлтийхийн үйлдүүлэх хэв.

ХЭЛТИЙХ хазайж түвшин тэгш биш болох; *өрөвсөн тийшээ хэлтийх; хажуу тийш хэлтийх; ачаа хэлтийх.*

ХЭЛТЛҮҮЛЭХ хэлтлэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЛТЛЭХ хэлтлэхэд хүргүүлэх; **хэлтлэх эмтлэх** х о р ш.; *боов хэлтэлж идэв.*

ХЭЛТРҮҮЛЭХ 1. хэлтрэхийн үйлдүүлэх хэв; 2. хэлтрэгдэх.

ХЭЛТРЭГДЭХ хэлтрэхийн үйлдэгдэх хэв.

ХЭЛТРЭСХИЙХ түр зуур буюу баахан хэлтрэх.

ХЭЛТРЭХ I юмнаас бяцхан эмтэрч хагарах, унах; **хэлтрэх сэлтрэх** х о р ш.; *шаазан хэлтрэх; мод хэлтрэх.*

ХЭЛТРЭХ II юмнаас ангижрах, гэтлэх; *ял хэлтрэх; торгууль татвараас хэлтрэх; тулгарсан аюулаас хэлтрэх;* **амь хэлтрэх** (аюул хөнөөлөөс амь мэнд ангижрах; б. алах ялаас өршөөгдөх).

ХЭЛТЧИХ байн байн хэлтлэх.

ХЭЛТЭГ а м ь т а н мөрөгтэй адил бөгөөд бие охор хэвэл их нэгэн зүйл загас.

ХЭЛТЭГНҮҮЛЭХ хэлтэгнэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЛТЭГНЭХ юмны хэлтэг хэлтэг хийх; *аяганы ширээ хэлтэгнэх.*

ХЭЛТЭЙ 1. хэл мэддэг; *монгол орос хэлтэй хүн;* 2. амтай, хэлэмгий; **хэлтэй амтай** (а. үг хэлэх хэлэлцэхдээ чадамгай, сүрхий; б. хэрүүл цуугианд дуртай); 3. сураг, мэдээтэй.

ХЭЛТЭЛЗЭХ 1. байн байн хэлтийх; 2. юмны хэлтэс хэлтэс хөдлөх; *газар хөдлөхөд байшин хэлтэлзэх шиг болов.*

ХЭЛТЭНХИЙ элж хагарсан юм; *хэлтэнхий аяга.*

ХЭЛТЭРХИЙ юмнаас хэлтэрч унасан бяцхан хувь; *аарууллын хэлтэрхий; шаазангийн хэлтэрхий.*

ХЭЛТЭС 1. албан байгууллагын дотор эрхлэх ажил хэргийн байдлаар хуваан салгаж тус тус ажил үүрэг эрхлүүлсэн газар; *ерөнхий хэлтэс; санхүүгийн хэлтэс; худалдааны хэлтэс; суртлын хэлтэс; зохиолын хэлтэс; төлөвлөгөөний хэлтэс;* 2. салаа, хувь; *бүхэл нэгэн цэцэг таван хэлтэс; үхэр хонины туурай хоёр хэлтэс;* **хэлтэс туурайтан** (ац туурайтан).

ХЭЛҮҮЛЭХ 1. хэлэхийн үйлдүүлэх хэв, хэлэхэд хүргүүлэх; *хүнээр хэлүүлэх; гэм бурууг ний өөрөөр нь хэлүүлэх;* 2. хэлэгдэх.

ХЭЛҮҮШТЭЙ хэлбэл зохистой, хэлмээр; *хэлүүштэй хэрэг; би нэг үг хэлүүштэй байна.*

ХЭЛХГЭР 1. дээл хувцасны элбэгдсэн буюу дээлээ ихэд хөөргөж бүсэлсний нь; *хэлхгэр дээл; хэлхгэр цув;* 2. хүн амьтны хэвэл хэвийн жишээнээс унжийж түнхийсэн нь; **хэлхгэр халхгар** х о р ш.; *хэлхгэр гэдэстэй; хэлхгэр биетэй; хэлхгэр тарган.*

ХЭЛХГЭРДҮҮЛЭХ хэлхгэрдэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЛХГЭРДЭХ хэтэрхий хэлхгэр болох.

ХЭЛХИЙЛГЭХ хэлхийхийн үйлдүүлэх хэв, хэлхийхэд хүргүүлэх.

ХЭЛХИЙХ хэлхгэр болох; *дээл хэлхийх; гэдэс нь хэлхийх.*

ХЭЛХМЭЛ хэлхсэн юм; *хэлхмэл яс; хэлхмэл сувд.*

ХЭЛХҮҮЛЭХ 1. хэлхэхийн үйлдүүлэх хэв; 2. хэлхэгдэх.

ХЭЛХЭГНҮҮЛЭХ хэлхэгнэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЛХЭГНЭХ хэлхгэр юмны хөдлөх, аашлах.

ХЭЛХЭЛДЭХ хэлхэхийн үйлдэлдэх хэв; *архи уугаад гудамжинд хэлхэлдэж явдаг хүмүүс байх юм.*

ХЭЛХЭЛЗЭХ хэлхгэр юмны хэлхэс хэлхэс хөдлөх.

ХЭЛХЭХ 1. нүх бүхий юманд дээс утас сүвлэн холбох торгох; *зоос хэлхэх; эрх хэлхэх; мөөг хэлхэх; ааруул хэлхэх; сувд хэлхэх;* 2. ш и л ж с э н салангид юмыг хооронд нь холбох; *баглаатай юмсыг хооронд нь хэлхэхгүй бол гээгдэнэ шүү.*

ХЭЛХЭЭ 1. хэлхээс, холбоос; *эрхний хэлхээ тасрав; ааруулын хэлхээ;* 2. ш и л ж с э н холбоо, холбогдол; *эр эмийн хэлхээ; ураг төрлийн хэлхээ;* 3. ш и л ж с э н хэрэг үйлийн чухал хураангуй, түүний холбогдол; *үйл ажлын товч хэлхээ; хэрэг заргийн хэлхээ;* 4. ш и л ж с э н авцалдаа, уялдаа; **хэлхээ холбоо** х о р ш.: *хойно байгаа зүйл нь өмнөхтэйгөө хэлхээ муутай байна; хэлхээ сайтай;* 5. номын заалт жагсаалт; *үгсийн хэлхээ; нэрсийн хэлхээ;* **хэлхээ яс** (араг яс).

ХЭЛХЭЭЛҮҮЛЭХ хэлхээлэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЛХЭЭЛЭХ 1. хэлхээсээр холбох, торгох; 2. холбоолох, сүлбээлэх, хуйвалдах.

ХЭЛХЭЭС хэлхэх утас дээс зэрэг юм; *эрхний хэлхээс.*

ХЭЛХЭЭТЭЙ 1. хэлхээ бүхий; *утсан хэлхээтэй;* 2. харилцан холбоо уялдаа бүхий.

ХЭЛЦЭХ хэлэлцэх, ярилцах.

ХЭЛЦЭЭ хэлэлцээ; **яриа хэлцээ** х о р щ.; *хэлцээ юу байх вэ.*

ХЭЛЦЭЭГҮЙ 1. хэлэлцэж ярилцаагүй, яриагүй; 2. сэтгэл дурнаа зохистой, яг таг тохирсон; *энэ хувцас над хэлцээгүй тохирчээ; хэлцээгүй сайхан орон сууц; хэлцээгүй сайхан эр.*

ХЭЛЦЭЭТЭЙ 1. хэлэлцээтэй, яриа ихтэй; *хэлцээтэй хэрэг; чамтай тун их хэлцээ бий;* 2. алдар цуутай, нэрд гарсан; *хэлцээтэй морь; хэлцээтэй хүүхэн.*

ХЭЛШГҮЙ хэлэхийн аргагүй, хэлж баршгүй; *хэлшгүй үг; хэлшгүй муухай амьтан.*

ХЭЛЭГДЭХ хэлэхийн үйлдэгдэх хэв, хэлэлцэгдэх; *муу хэлэгдэх; сайн хэлэгдэх.*

ХЭЛЭЛЦҮҮЛЭХ хэлэлцэхийн үйлдүүлэх хэв, хэлэлцэхэд хүргүүлэх, нийтэд ярилцуулах; *олноор хэлэлцүүлэх; нийтээр хэлэлцүүлэх; хурлаар хэлэлцүүлэх.*

ХЭЛЭЛЦЭХ 1. хэлэхийн үйлдэлцэх хэв, харилцан ярилцах; 2. олноор буюу бусдын хамт хэлэх; *шүүмжлэн хэлэлцэх; хурал дээр зөвлөн хэлэлцэв;* **хэлэлцэх хэрэг** (хурал зөвлөлгөөнөөр ярилцах хэргийн товьёг жагсаалт); **хэлэлцэх асуудал** (ярилцвал зохих хэрэг).

ХЭЛЭЛЦЭЭ (Н) үйл хэрэгт ийн тийн зөвлөлдөн хэлэлцэх нь, хэлцээ; **яриа хэлэлцээ** х о р ш.; **хэлэлцээ хийх** (а. хэлэлцээ болох; б. ямар нэгэн үйл ажлыг гүйцэтгэх тухай харилцан тохиролцох): **ам хэлэлцээ** (ам тохиролцоо); **хэлэлцээ гарах** (хэлэлцэхэд хүрэх сэдэв гарах, ярьж ярилцах хэрэг гарах).

ХЭЛЭЛЦЭЭР 1. аль нэгэн асуудлын талаар харилцан тохиролцсон гэрээ; *нууц хэлэлцээр;* 2. аль нэгэн асуудлын талаар харилцан тохиролцохын тулд хийсэн яриа зөвлөлгөөн; *хилийн хэлэлцээр хийсээр байна; хэлэлцээрт оролцох.*

ХЭЛЭМГИЙ хэлэх ярихдаа түлбэрэхгүй шууд; **хэлэмгий доломгой** х о р ш..

ХЭЛЭМГИЙВТЭР нилээд хэлэмгий.

ХЭЛЭМГИЙДЭХ хэтэрхий хэлэмгий болох.

ХЭЛЭМГИЙРХҮҮ нилээд хэлэмгий, хэлэмгийхэн.

ХЭЛЭМГИЙРХҮҮЛЭХ хэлэмгийрхэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЛЭМГИЙРХЭХ хэлэмгийгээ гайхуулхийлан их л хэлэх өгүүлэх.

ХЭЛЭМГИЙТЭХ хэлэмгий зан байдал гаргах.

ХЭЛЭМГИЙХЭН баахан хэлэмгий, арай хэлэмгий.

ХЭЛЭХ өгүүлэх ярих; *үг хэлэх; үлгэр хэлэх; хэлж бичүүлэх; хэлэхэд бэлэн, хийхэд бэрх; саналаа хэлэх; худал хэлэх; үнэнээ хэлэх гэсэн юм; би чамд эс хэлэв үү; хэлж өгөхөд чих чинь цоорхой, хийж өгөхөд сав чинь цоорхой* з ү й р.

ХЭМ I ц аг улирлын урт охрын хэмжээ; **хир хэм** х о р ш.; *арван цагийн хэм; өдрийн уртын хэм; шөнийн богиныг хэм; өдөр дүлийн хэм;* 2. юмны их бага, өргөн явцуу зэргийн хир хэмжээ; **хэм хэмжээ** х о р ш.; *өндрийн хэм; өргөний хэм; хол ойрын хэм; олон цөөний хэм; нимгэн зузааны хэм.*

ХЭМ II амьтны ясны дотоод тос нүмжиг; *ясны хэм; өвчүүний ясны хэм;* **хэм суух** (амьтны яс сийлмийж хэмтэй болох).

ХЭМЖИГДЭХҮҮН 1. хэмжээ; *талбайн хэмжигдэхүүн;* 2. хэмжигдэхэд өртөгдөх юмс; *тэнцүү хэмжигдэхүүн.*

ХЭМЖИГЧ хэмжих үйл гүйцэтгэгч.

ХЭМЖИЛ хэмжсэн нь; *дөрвөлжинд хоёр хэмжил бий.*

ХЭМЖИХ аливаа хэмжүүрээр буюу багцаалах мэтээр юмны хэмжээ баргийг олохоор хэмнэх; *газар хэмжих; өндрий нь хэмжих; мал хэмжих; зайгий нь хэмжих; эзлэхүүнийг хэмжих;* **хэмжих ухаан** (орон зайн хэлбэр, түүнийг хэмжих зүй тогтоолыг судлах, тооны ухааны салбар).

ХЭМЖҮҮЛЭХ 1. хэмжихийн үйлдүүлэх хэв; 2. хэмжигдэх.

ХЭМЖҮҮР юмны үлэмж хомсыг хэмнэх зэвсэг багаж; *хүнд хөнгөний хэмжүүр; урт охрын хэмжүүр; овор багтцын хэмжүүр.*

ХЭМЖҮҮРДЭХ хэмжүүр авах, хэмжих.

ХЭМЖҮҮРЛЭХ 1. хэмжих; 2. хэмнэж хомстгох.

ХЭМЖЭЭ 1. юмны урт богино, өргөн нарийн, өндөр нам, хүнд хөнгөн, их бага зэргийн хэм; **хир хэмжээ, багцаа хэмжээ** х о р ш.; **хэмжээ авах** (юмны хэмийг хэмнэн мэдэх); **хэмжээ тогтоох** (хэмжээ хугацаатай болгох), **хэмжээ хязгааргүй** (маш их, хэмжихэд бэрхтэй); **хэмжээ тавих** (юмыг хэмжиж тусгайлан тэмдэг тавих): **насны хэмжээ болох** (а. насны туйлд хүрэх; б. нас эцэслэх); 2. аливаа хэмжүүр; 3. даввал болохгүй тогтсон ёс; **хууль хэмжээ, дүрэм хэмжээ, хэмжээ хязгаар, хэм хэмжээ** х о р ш.; 4. засах залруулах арга; **арга хэмжээ** х о р ш.; *арга хэмжээ авах);* **хэмжээ өгөх** (а. гэмт хүнд буруушаал зэмлэл ногдуулах; б. хийлгэх үйлдүүлэх юмны хэмнийг авахуулах ба мэдэгдэх): **хэмжээ үзүүлэх** (хэмжээ өгөх); 5. ш и л ж с э н даяар; *сумын хэмжээгээр; аймгийн хэмжээгээр; улсын хэмжээгээр;* 6. ш и л ж с э н хир, чинээ; *мэдлэгийн хэмжээгээр; боловсролын хэмжээ; чадлын хэмжээгээр.*

ХЭМЖЭЭГҮЙ 1. хэм хэмжээ байхгүй; 2. хязгааргүй.

ХЭМЖЭЭЛҮҮЛЭХ хэмжээлэхийн үйлдүүлэх хэв.

ХЭМЖЭЭЛШГҮЙ 1. хэмжиж болшгүй, хязгаарлашгүй; 2. арван тоолшгүй буюу жаран нэгэн оронтой тоо.

ХЭМЖЭЭЛЭХ 1. юмыг хэмжүүрээр хэмнэх; 2. хязгаарлах, хэмжээтэй болгох.

ХЭМЖЭЭС хэмжээ бүхий, хэмжиж тогтоосон нь; *зургийн хэмжээс.*

ХЭМЖЭЭСЛЭХ хэмжээтэй болгох, хэмжээ тогтоох.

ХЭМЖЭЭТ хэмжээ бий; **хэмжээт эрх** (хязгаартай эрх); **хэмжээт эрх хаант засаг** (хааны эрхийг хязгаартай болгосон засгийн хэлбэр).

ХЭМЖЭЭТЭЙ хэмжээ бүхий; *хоёр метрийн хэмжээтэй банз; гурван цагийн хэмжээтэй; хэмжээтэй унтах; хэмжээтэй идэх; хэмжээтэй ажил.*

ХЭМЛЭЛ алив жигд хэм бүхий сэлгэл; *хөгжмийн хэмлэл; шүлгийн хэмлэл.*

ХЭМЛЭХ яс зэргийн юмыг зажлах түлхэх, мэрэх зэргээр идэх буюу тос шүлтийг амтлах; *ааруул хэмлэх; яс хэмлэх.*

ХЭМНҮҮЛЭХ 1. хэмнэхийн үйлдүүлэх хэв; 2. хэмнэгдэх.

ХЭМНҮҮР цаг улирлын урт охор, агаар амьсгалын өтгөн шингэн, халуун хүйтний үлэмж хомс зэргийг хэмнэх хэрэглэлийн нийтийн нэр, хэмжүүр; *секунд хэмнүүр.*

ХЭМНЭГ 1. алив юмны хоорондын тохиролцоо, пропорц; *хэмнэг чанар;* 2. тоо бодлогын ухааны хоёр харьцааны тэгшитгэл.

ХЭМНЭГДЭХ хэмнэхийн үйлдэгдэх хэв.

ХЭМНЭЛ I хэмнэх үйлийн нэр, хэмжил.

ХЭМНЭЛ II арвилал, гамнал.

ХЭМНЭЛЭГ хэмнэх үйлийн нэр, арвилал, гамнал.

ХЭМНЭХ I 1. цаг уур ба агаар амьсгал эсэхүл халуун хүйтнийг тусгай багаж хэрэглэлээр буюу багцаагаар боловч хэмжих бараглах; 2. хэмжих.

ХЭМНЭХ II арвилах, гамнах; *зардал сүйтгэл хэмнэх; эдлэх хэрэглэхэд ариглан хэмнэх.*

ХЭМРЭХ амьтны ясны хэм болох.

ХЭМТ хэм бүхий, хэмжүүр бүхий; **хэмт гуурс** (эмийн сан, лаборатори зэрэгт хэрэглэх, шингэн зүйлийг хэмжих хэмжүүр бүхий сав).

ХЭМТЭХ хэмтэй болох; *чөмөг нь хэмтэх.*

ХЭМХ I 1. тарвасын өөр нэр; **өргөст хэмх** у р г а м а л (хулуугийн намын таримал ногоо, иддэг, гонзгойвтор ногоон үр жимстэй); 2. тарвасын дотоод үр.

ХЭМХ II хүч нэмэгдүүлэх үг; *хэмх татах; хэмх цохих; хэмх унах.*

ХЭМХДЭГ нүдэгдэх, дарагдах зэргээр хэмхэрч үүрмэг бутархай болсон юм; *тариа будааны хэмхдэг; чулуу модны хэмхдэг; сагагийн хэмхдэг.*

ХЭМХДЭС хэмхэрч бутарсан юм; *төмрийн хэмхдэс.*

ХЭМХЛҮҮЛЭХ 1. хэмхлэхийн үйлдүүлэх хэв; 2. хэмхлэгдэх.

ХЭМХЛҮҮР хэмхлэх зэвсэг, юмыг цохиж нүдэж, няцлах хэмхлэх уур сав ба маншуу муна.

ХЭМХЛЭХ хэмхрэхэд хүрүүлэх.

ХЭМХРЭХ үүрэх, хагарах, эвдрэх; **эвдрэх хэмхрэх, хагарч хэмхрэх** х о р ш.; *чулуу хэмхрэх; авдар сав хэмхрэх; барилга хэмхрэх.*

ХЭМХЧИХ бүхэл бүтэн юмыг хагалж эвдэж үүрүүлэх хэмхлэх.

ХЭМХЧҮҮЛЭХ хэмхчихийн үйлдүүлэх хэв.

ХЭМХЭРХИЙ 1. эвдэрч хэмхэрсэн юм; *хэмхэрхий ширээ;* 2. хэмхэрч эвдэрсэн хэсэг; *шилний хэмхэрхий.*

ХЭМХЭХ амьтны нэг нэгнээ буюу өөр амьтныг дийлэн зууж үнхэх, шархтаах; *нохой хэмхэх.*

ХЭМШИХ хэм болох, хэмрэх.

ХЭМЭЛ 1. самар шидийн цөмөө байхгүй хоосны нь; *хэмэл самар;* 2. даравч зулзага гарахгүй өндөг; *хэмэл өндөг.*

ХЭМЭРД галбинга шувууны өөр нэр.

ХЭМЭРЛЭГ I хоргой; *хэмэрлэг дээл.*

ХЭМЭРЛЭГ II: **хэмэрлэг гургуул** а м ь т а н өвөг алтан өнгөтэй, хүзүүн дээр хар хөвөөтэй, алтлаг ногоон өнгөтэй өд бий нь зах мэт үзэгдэнэ, нуруу ба сүүлийн дээд тал шар, мөр дээрх өд хар хөх, хөл боровтор, гургуулын нэгэн зүйл шувуу.

ХЭМЭРСЭН: хэмэрсэн цэцэг у р г а м а л ороож ургадаг нэг зүйл цэцэг, зэл нарийн болоод урт, хаврын сүүл хирээр цэцэглэнэ, улаан цагаан хоёр зүйл бий.

ХЭМЭЭВЧ б и ч и г хэмээх боловч, гэвч; *олон хэмээвч хүрэлцэхгүй; ололт бий хэмээвч басхүү дутагдал бий.*

ХЭМЭЭН б и ч и г гэж; *зүйтэй хэмээн зөвшөөрнө; сайн хэмээн магтана.*

ХЭМЭЭХ б и ч и г 1. гэх; *алт хэмээх эрдэнэ; арслан хэмээх араатан;* 2. өгүүлсэн дурдсан юмыг заах үг; *түүнийг хүн тийм хэмээх нь бий; энэ хэргийг ийм хэмээх нь зүйтэй.*

ХЭН асуух төлөөний үг, гагцхүү хүн төрөлхтөнд хэрэглэнэ; *нэр хэн бэ? тэр хэн бэ? үүнийг хэн хэлэв? танайд хэн хэн ирэв? чи хэн хэнийг таних вэ? хэн гэгч тэр вэ? хэнээс авав? хэнээс сонсов?;* **хэн тэгш** (ялгаваргүй адил; *хэн тэгш хувааx хэрэгтэй; хэн тэгш ажиллах ёстой);* **хэн мэдэх вэ** (мэдэхгүй гэж баахан ущаарлах үг); **хэн хүнгүй, хэн хэнгүй, хэн янгүй** (байгаа хүн цөмөөрөө, бүгдээрээ).

ХЭНГЭНЭХ гэншин дуугарах дууны урт үргэлжлэн гарах; *хэнгэнэн үйлах; хэнгэнэн буйлах.*

ХЭНГЭРЭГ (ХЭНГЭРГЭН) цохих хөгжмийн зэвсэг, дүгрэг цагаригийн хоёр этгээдийг арьсаар бүрж хийнэ; *хэргийн эвэн, хэнгэргийн дохиур* з ү й р; **дийлсэн хэнгэрэг дэлсэх** (дийлсэндээ бахархах); ☆ **чихний хэнгэрэг, хэнгэргэн хальс** (дунд чих сонсголын сүв хоёрыг тусгаарласан 0,1 мм. нимгэн хальс); **хэнгэрэг од** з у р х а й (дамнуур од); **хагархай хэнгэрэг** (ам задгайтай, дэмий яримтгай; *хагархай хэнгэрэг цуурхай цан шиг* з ү й р).

ХЭНГЭРЭГДЭХ хэнгэрэг цохих.

ХЭНДЭХ өвчин ялаарьшиж байгаад дахин үгдрэх.

ХЭНЗ 1. малын төл зохих хэмээс их л хожим орой төрсний нь; *хэнз хурга; миний хэнз хурга магнай халзан зурвастай, мянган хонины дундаас би хармагц таньдаг* (Д. Нацагдорж); 2. намаршиж цаг орой болсон хойно ургасан ногоо; *хэнз ногоо;* **хэнз өрөм** (намар сэрүүн цагт хураасан өрөм).

ХЭНЗДҮҮЛЭХ хэнздэхийн үйлдүүлэх хэв.

ХЭНЗДЭХ хэтэрхий хэнз болох.

ХЭНЗЛҮҮЛЭХ хэнзлэхийн үйлдүүлэх хэв.

ХЭНЗЛЭХ 1. аливаа малын хэнз төл төрөх; *хонь хэнзлэх; ямаа хэнзлэх;* 2. намрын цагт ногоо соёолж дахин ургах; *ногоо хэнзлэх.*

ХЭНИЙХ хэний харьяаны болохыг лавлахад хэрэглэх үг; *чи хэнийх вэ? энэ ном хэнийх вэ?*

ХЭНТЭГ ялимгүй зүйлд буюу нэндүү хүлцэлгүй уурсах сочмог зантай хүн.

ХЭНТЭГЛҮҮЛЭХ хэнтэглэхийн үйлдүүлэх хэв.

ХЭНТЭГЛЭХ хэнтэг зан гаргах.

ХЭНТЭГТЭЙ хэнтэг зантай.

ХЭНҮҮР а м ь т а н бугатай адилхан, модонд авирч чаддаг нэгэн зүйл гөрөөс.

ХЭНХГЭНҮҮЛЭХ хэнхгэнэхийн үйлдүүлэх хэв.

ХЭНХГЭНЭХ хэнхгэр юмны хөдлөх.

ХЭНХГЭР хүн амьтны бие хэвийн жишээнээс том, ханхгар, янхигар, дорвилгий нь; *хэнхгэр цээжтэй.*

ХЭНХДЭГ цээжин биеийн өмнө тал.

ХЭНХИЙЛГЭХ хэнхийхийн үйлдүүлэх хэв; *цээжээ хэнхийлгэх.*

ХЭНХИЙХ хэнхгэр байдалтай болох.

ХЭНХИН а м ь т а н баавгайтай адил дүрстэй нэгэн зүйл амьтан.

ХЭНХМЭЛ хашир догь; *хашир хэнхмэл хүн; хэнхмэл зантай хүүхэд.*

ХЭНХРЭГ 1. цээжин биеийн араг яс; 2. хэнхдэг.

ХЭНХЭГ 1. хоолонцор, хоол маш хүсэмтгий, хэтэрхий их идэмхий; 2. хэвийн хэмээс хэтэрхий; *үгийн хэнхэг; ярианы хэнхэг; айл хэсэхийн хэнхэг; зүгээр суухын хэнхэг.*

ХЭНХЭГЛЭХ хэнхэг болох.

ХЭНХЭГРЭХ хэнхэг байдалтай болох.

ХЭНХЭЛЗҮҮЛЭХ хэнхэлзэхийн үйлдүүлэх хэв.

ХЭНХЭЛЗЭХ хэнхгэр юмны хэнхэс хэнхэс хөдлөх.

ХЭНХЭРЦЭГ хэнхрэг, хэнхдэг; *цээжний хэнхэрцэг.*

ХЭНШИГ нүмжигтэй идээний зүйлийн тааламжтай үнэр; *хоолны газраас хэншиг үнэр үнэртэж хорхой хүргэв.*

ХЭНШИГХЭН баахан хэншиг, нилээд хэншиг.

ХЭНШИХ I элдэв идэшний зүйлийг хуурах буцалгахад бяцхан түлэгдэж хэншүүн үнэр амт орох.

ХЭНШИХ II хий хуурай ханиах.

ХЭНШҮҮ эвэрлэг ба үсний зүйл, эсэхүл мах тосны зэрэг юмыг хуйхалсан түлснээс гарах нэгэн зүйл үнэр: **хэншүү хярвас** х о р ш.; *хэншүү үнэртэх;* **хэншүү тавих** (хэншүү гаргах).

ХЭНШҮҮН юманд хэншүүний үнэр амт баахан байгаагий нь.

ХЭНЭГГҮЙ хүний санаа уудам, увайгүй, тоомсоргүй зантай; *биеэ үгүйлэхгүй, хэнэггүй зан битгий гаргаж яв!*

ХЭНЭЭ 1. хүний ухаан мэдрэл гэмтэж солиу бүдэх болсны нь; *сэтгэлийн хэнээтэй хүн; хэнээ өвчин тусах;* 2. хирээс хэтэрхий хүслэн; *эдийн хэнээ; хоолны хэнээ; тоглоомын хэнээ.*

ХЭНЭЭРХЭЛ хэнээрэх үйлийн нэр; *хэнээрхэл нь хөдлөх; дайны хэнээрхэл.*

ХЭНЭЭРХЭХ 1. хэнээтэй хүний хэнээ өвчин хөдлөх; 2. юманд хэтэрхий хүслэн болох.

ХЭНЭЭРЭЛ хэнээ, хэнээрхэл; *дайны хэнээрэл; хоолны хэнээрэл.*

ХЭНЭЭРЭХ хэнээрэл болох.

ХЭНЭЭТЭЙ хэнээ бүхий; *хэнээтэй хүн; хэнээтэй амьтан.*

ХЭНЭЭТЭХ хэнээ өвчин тусах.

ХЭР I гур зүрийн үс ургаад асар удаж, хэврэгшээгүй бэх чийрэг үеийн арьс.

ХЭР II: **хэр хэр хийх** сонсоход хэр хийх дуу чимээ дахин дахин гарах; *хэр хэр ханиах; хэр хэр дуугарах.*

ХЭРВИХ I юмны зах сэжүүрийг аятайгаар танаж хасах.

ХЭРВИХ II тэмээний өвс идэш хазсаар үүдэн шүдний хурц нь мохож элэгдэх; *гол хоёроо хэрвих; дөрөв хэрвих; тэгш хэрвих.*

ХЭРВЭЭ хэрэв.

ХЭРВЭЭС хэрвисэн хэсэг, танаас.

ХЭРВЭЭСЛЭХ танаж авах.

ХЭРГЭМ х у у ч и р с а н гавьяат хүмүүст олгож байсан цол ба зэрэг; **хэргэм зэрэг** х о р ш.; *вангийн хэргэм; гүнгийн хэргэм; түшмэлийн хэргэм; хэргэм залгамжлах.*

ХЭРГЭМТЭН хэргэм бүхий этгээд.

ХЭРД: **хэрд хийх** хатуухан юмыг хазах зажлахад гарах чимээ.

ХЭРДЭС хэрж ороосон юм, ороомог; *төмөр утсан хэрдэс.*

ХЭРДЭСЛЭХ хэрэх, ороох; *утас хэрдэслэх.*

ХЭРЗГЭР I хэвийн жишээнээс туранхай буюу арьс давхацлагагүй юм; **хэрзгэр харзгар** х о р ш; *хэрзгэр яс; хэрзгэр хавирга.*

ХЭРЗГЭР II хэдэр, хэвцгий ааштай.

ХЭРЗИЙЛГЭХ хэрзийхийн үйлдүүлэх хэв.

ХЭРЗИЙХ I хэрзгэр харзгар болох.

ХЭРЗИЙХ II хэдэр хэвцгий зан гаргах.

ХЭРИГ эд юмаа нэндүү хайрлах, харамсах зантай; **харамч хэриг** х о р ш..

ХЭРИГЛЭХ хэриг ааль гаргаж, эд юмыг нэн ихээр хайрлан харамсах, хэтэрхий харамлах.

ХЭРЛЭХ гөрөөсний үс хэр болох.

ХЭРМЭЛ I 1. тэнэмэл хүн; **хэрмэл тэнэмэл** х о р ш.; 2. захиргаагүй завхуул; *хэрмэл бадарчин.*

ХЭРМЭЛ II утас мэтээр хэрсэн юм.

ХЭРМЭЭ а м ь т а н далайд орших ногоовтор өнгөтэй нэгэн зүйл загас.

ХЭРМЭЭН а м ь т а н зарам загасны адил болоод маш тарган нэгэн зүйл загас.

ХЭРС I у р г а м а л далайн эрэг, давст нууры захаар ургадаг нэг зүйл өвс.

ХЭРС II артай нэгэн зүйл ногоон чулуу.

ХЭРС III а м ь т а н сүүн тэжээлт нэгэн зүйл амьтан, бие том, болхи бядуу, ургамлын зүйлээр амьдрана, толгой уртхан; хоншоорт нэг буюу хоёр эвэр бий, арьс маш зузаан бөгөөд нүцгэн, атираа үлэмж, нүд бяцхан.

ХЭРСҮҮ I үйл явдалд хашир хянамгай, болгоомж сэрэмж сайтайгий нь; **хашир хэрсүү** х о р ш.; *хэрсүү хүн; хэрсүү юунаас гэвэл хаширснаас, хэрсэн юунаас гэвэл таргалснаас* з үй р.

ХЭРСҮҮ II нумны галжирлаж хөвч нь мултарч буухыг сэргийлж баатрын дэргэд тавьж бэхлэх хайгуулын нэр, мод эвэр яс мэтээр хийнэ; *нумны хэрсүү.*

ХЭРСҮҮДЭХ хэтэрхий хэрсүү болох.

ХЭРСҮҮЛЭХ хэрсүү зан байдал гаргах, хэрсүү нь дэндэх.

ХЭРСЭГ байшин барилгад янз болгож барьсан намхан хашаа, хайс.

ХЭРСЭГЛҮҮЛЭХ хэрсэглэхийн үйлдүүлэх хэв.

ХЭРСЭГЛЭХ хэрсэг хийх; хэрсэгтэй болгох.

ХЭРСЭН мал гөрөөсний өвчүүний бүдэрхий ба аймхайн хоорондох мах арьс; *өвчүүний хэрсэн.*

ХЭРҮҮ уулын ар газар, хүй хүйгээр ягц ургасан мод; *ойн хэрүү; хэрүү мод.*

ХЭРҮҮЛ хүн амьтны санаа тохирохгүй харилцан тэмцэж цуугих, маргахы нь; **хэрүүл тэмцэл, хэрүүл баруул, хэрүүл цуугиан, хэрүүл доруул** х о р ш.; *хэрүүл өдөх; хэрүүл өдөөх;* **хэрүүл хийх** (хэрэлдэх).

ХЭРҮҮЛЧ хэрүүлд дуртай, хэрэлдэмтгий; *хэрүүлч хүн хээр хонох* з үй р.

ХЭРҮҮЛЭХ 1. хэрэхийн үйлдүүлэх хэв; 2. хэрэгдэх.

ХЭРХНЭГ сайн сархинаг буюу цоохор гүзээ.

ХЭРХЭВЧ яавч; *хэрхэвч үл бүтэх хэрэг; хэрхэвч хүрэлцэнэ; хэрхэвч чадахгүй; хэрхэвч няцахгүй.*

ХЭРХЭН яаж; *энэ үйл хэрхэн ийм болов? одоо хэрхэн явуулбал зохих вэ?* 2. ямар гэх санаа; *би ингэж хийх гэж бодож байна, чиний санаанд хэрхэн санагдана? энэ хэргийг хэрхэн болгохыг тогтооно уу.*

ХЭРХЭХ I яах *хэрхэх вэ? хэрхвэл зохихыг заана уу ;хэрхвэл дээр вэ?*

ХЭРХЭХ II хэвцэглэх, хэрцгийлэх.

ХЭРЦГИЙ зан ааль хэдэр, санаа явдал нийцгүй; **хэдэр хэрцгий, хэрцгий догшин** х о р ш.; *хэрцгий зан гаргах; чи яасан хэрцгий амьтан бэ.*

ХЭРЦГИЙВТЭР баахан хэрцгий, арай хэрцгий.

ХЭРЦГИЙДЭХ хэтэрхий хэрцгий болох; *хэрцгийдээд огт ярьж болохгүй хүн байна.*

ХЭРЦГИЙЛҮҮЛЭХ хэрцгийлэхийн үйлдүүлэх хэв.

ХЭРЦГИЙЛЭХ хэрцгий зан байдал гаргаж авирлах.

ХЭРЧИГДЭХ хэрчихийн үйлдэгдэх хэв.

ХЭРЧИГНҮҮЛЭХ хэрчигнэхийн үйлдүүлэх хэв.

ХЭРЧИГНЭХ хатуухан юмыг зажлахад хэрчиг хэрчиг дуу гарах; *хужирхай хэрчигнэтэл зажилж байв.*

ХЭРЧИМ зарим нэгэн юмыг хэрчин огтолж хэсэглэсэн бяцхан хувь; *хэрчим түлээ; хэрчим мах; хэрчим гэдэс.*

ХЭРЧИХ хутга хэрчүүрийн зэрэг ирт зүйлээр юм хумыг огтлох, хэсэглэх; *мах хэрчих; түлээ хэрчих; гараа хэрчих.*

ХЭРЧЛЭХ байн байн хэрчих.

ХЭРЧЛЭЭ хэрчлээс, хэрчээс.

ХЭРЧЛЭЭС хэрчээс, хэрчлээ.

ХЭРЧМЭГ 1. бяцхан болгон хэрчиж хатаасан мах; 2. хэрчмэл юм.

ХЭРЧМЭЛ тусгайлан хэрчсэн юм, хэрчмэг.

ХЭРЧҮҮЛЭХ 1. хэрчихийн үйлдүүлэх хэв; 2. хэрчигдэх.

ХЭРЧҮҮР юмыг огтолж цавчин хэрчих зэвсэг.

ХЭРЧЭЭ моголцоглон хэрчсэн хэрчмэл хэлбэртэй нэгэн зүйл боов.

ХЭРЧЭЭС юмны хэрчсэн ором; *хэрчээс гаргах; хэрчээстэй мод; хэрчээстэй шил сав.*

ХЭРЧЭЭСЛЭХ хэрчээс гаргах.

ХЭРЭВ аливаа үйл хэрэгт магадлаж болом-гүй сэжиглэх газарт хэрэглэх үг, хэрвээ; *ус гүйхэн бол мориор туулна; хэрэв гүнзгий бол хөлгөөр гэтэлнэ; ажил хийвэл хоол иднэ, хэрэв эс хийвэл хоосон хононо; хэрэв зорьсоноо хүрэхгүй бол доо чамайг.*

ХЭРЭГ 1. албан амины ажил, үйл явдлын чиглэлт; *албаны хэрэгтэй яваа; хувийн хэргээр хөдөө явах; санасан хэрэг чинь сэтгэлчлэн бүтэх болтугай! хэрэг зориг хэнд вэ, хэт нутаг хаана вэ* (үлгэрээс); **ажил хэргийн чанартай** (жинхэнэ ажил болгох, биелүүлэх тухайтай); 2. албан баримт; *албан хэргийг цэгц журамтай хөтлөх;* **бичиг хэргийн эрхлэгч** (албан баримт сэлтийг хариуцагч албан тушаал): **нууц хэрэг** (албаны нууц баримт бичиг сэлт); 3. тус, хэрэгцээ; *энэ ном чинь над их хэрэг болно; чиний цуглуулганд хэрэг болох юм олон байна; эрдэм сурвал аминд хэрэг болно;* 4. хууль зөрчсөн гэмт үйл явдал; **хэрэг зарга** х о р ш.; **улс төрийн хэрэг** (улс төрд тэрсэлсэн гэмт явдал); **гэмт хэрэг** (хууль зөрчсөн гэмт явдал); **амины хэрэг** (а. бусдын амьтай холбогдсон хэрэг; б. албаны биш хэрэг, өөрийн хэрэг); **хэрэг алдах** (а. эндэгдэж буруу хэрэг хийх: б. тэмцэн заалдаж бусдад дийлдэх, ялагдах); **хэрэг тарих** (а. гэмт хэрэг үйлдэх; б. яршиг төөг тарих); **хэргийн эзэн** (үйлдсэн гэмт явдлын чухам эзэн); **хэрэгт орох** (гэмт явдалд холбогдох); **хэрэг халдах** (хүний гэмт явдал бусдад нялзах); **хэрэг бүртгэх** (үйлдсэн гэмт явдлын хэрэглэгдэхүүн зэргийг цуглуулах); **хэрэгт холбогдох** (хуульд харштай гэмт явдалд холбогдох): **хэрэгт татагдах** (хуульд харштай явдалд холбогдож баригдах); **хэрэг мөшгөх** (хэрэг мөрдөх); **хэрэг шүүх** (үйлдсэн гэмт явдлыг нягтлан шүүх); **хэрэг мөрдөх** (үйлдсэн гэмт явдлыг дэс дараалан шүүж мөрдөх, мөшгөх); **хэрэг байцаах** (гэмт явдлыг нягтлан шалгах); **хэрэг мэдүүлэх** (үйлдсэн гэмт явдлаа тоочин хэлэх); **хэрэг хүлээх** (өөрийн үйлдсэн гэмт явдлыг хийснээ зөвшөөрөн хүлээх); **хэрэг хүлээлгэх** (үйлдсэн гэмт явдлыг тулган хүлээлгэх): **хэрэг нэхэмжлэх** (өшгөрсөн хэрэг явдлыг нэхэмжлэн үүсгэх сөхөх); **хэрэг цагаатах** (алив гэмт явдалд ял холбогдолгүй болох).

ХЭРЭГГҮЙ 1. хэрэг байхгүй, хэрэгцээгүй, тусгүй; *авах хэрэггүй; өгч хэрэггүй; хэрэггүй болгох; хэрэггүй юм;* 2. зүгээр, дэмий; *хэрэггүй тэнэж явна.*

ХЭРЭГЛҮҮЛЭХ хэрэглэхийн үйлдүүлэх хэв. *гэр хэрэглүүлэх; орон сууц хэрэглүүлэх; уналга ачлага хэрэглүүлэх; мөнгө төгрөг хэрэглүүлэх.*

ХЭРЭГЛЭГДЭХ хэрэглэхийн үйлдэгдэх хэв; *гэрт хэрэглэгдэх эд хогшил; барилгад хэрэглэгдэх эд материал; хүнсэнд хэрэглэгдэх мал мах; зүтгэх хүчинд хэрэглэгдэх хөсөг; нийтэд хэрэглэгдэх бараа таваар.*

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН аливаа юмыг хийж үйлдэхэд хэрэглэгдэх юм; *шинжилгээний хэрэглэгдэхүүн; архивын хэрэглэгдэхүүн.*

ХЭРЭГЛЭЛ үйл ажилд хэрэглэх эд хэрэгсэл; *бичгийн хэрэглэл; гэрийн хэрэглэл; эмээлийн хэрэглэл; зөвсөг хэрэглэл; цалин хэрэглэл;* **хуурай хэрэглэл** (болгож боловсруулаагүй идэш уушны зүйл).

ХЭРЭГЛЭХ юмыг өөрийн хэрэг тусад ашиглах, эдлэх, авах, туслалцуулах; *хүчий нь хэрэглэх; эд мөнгө хэрэглэх; эрдмий нь хэрэглэх; зөвсөг багаж хэрэглэх.*

ХЭРЭГЛЭХҮҮН хүний аливаа хэрэглэх юмс, хэрэглэх зүйлс.

ХЭРЭГСҮҮЛЭХ хэрэгсэхийн үйлдүүлэх хэв.

ХЭРЭГСЭЛ аливаа юманд хэрэглэгдэх зүйл; *гэрийн хэрэгсэл; бичгийн хэрэгсэл; тариалангийн хэрэгсэл; бүрэн хэрэгсэлтэй эмээл; барилгын хэрэгсэл;* **үйлдвэрлэлийн хэрэгсэл** (хөдөлмөрийн хэрэглэгдэхүүн хөдөлмөрийн багаж зэвсэг).

ХЭРЭГСЭХ 1. хэрэглэх; *уналга ачлага хэрэгсэх; хоол хүнс хэрэгсэх; хувцас хунар хэрэгсэх;* 2. үйл ажлыг ойшоож тоомсорлох; *хэрэгсэн үзэх; эс хэрэгсэх шинжтэй байна.*

ХЭРЭГСЭХГҮЙ үл хэрэгсэх; *гуйсан гуйлтыг хэрэгсэхгүй болгосугай.*

ХЭРЭГТЭЙ 1. хэрэг бүхий юм, хэрэгцээтэй юм; *хэрэгтэй ном; хэрэгтэй хүн; хэрэгтэй зүйлүүд;* 2. ёстой, зохистой; *чи гуйцэтгэх хэрэгтэй; өдөр бүрийн нормыг давуулан биелүүлж байх хэрэгтэй: бүх хүчээ дайчлан ажиллах хэрэгтэй.*

ХЭРЭГТЭН гэмт хэрэгт орсон, холбогдсон этгээд; *хэрэгтэн этгээд; хэрэгтний өчиг мэдүүлэг; хэрэгтний өмгөөлөгч.*

ХЭРЭГЧИН бор гөрөөсний эм, зүр ч гэдэг.

ХЭРЭЛ өтөг, хөрзөн; **хэрэл шатах** (хөрзөн өтөг шатах).

ХЭРЭЛДҮҮЛЭХ хэрэлдэхийн үйлдүүлэх хэв, хэрэлдэхэд хүргүүлэх.

ХЭРЭЛДЭГ а м ь т а н баавгайтай адил бөгөөд бяцхан, үс ноорхой нэгэн зүйл амьтан.

ХЭРЭЛДЭХ 1. санаа нийлэхгүй харилцан хэрүүл болох; *энэ өдөр хоёр хүн хэрэлдэж байв;* 2. нохойн тэмцэлдэн ноцолдох; *нохой хэрэлдэх.*

ХЭРЭЛЗГЭНЭ хээрийн хулгана.

ХЭРЭМ (ХЭРМЭН) I 1. а м ь т а н ойн мэрэгчдийн төрөл, жижиг амьтан, сүүл урт бөгөөд сахлаг үстэй, чих урт, өнгө улаан бор, хар болж хувирна, шилмүүст ой модонд оршино, самар ба шогшгойг иднэ, арьс үнэтэй; **хэрэмний хорил, хэрэмний хонгио** (хэрэмний орших үүр); **хар хэрэм** (Ангар мөрний орчмоор орших нэг зүйл хар зүсмийн хэрэм); **хув хэрэм** (хөгширсөн эм хэрэм); **хэрмэн сүүл у р г а м а л** (а. 15—50 сантиметр ургадаг нэг наст ургамал, түрүү нь үнэг хэрэмний сүүл адил, цэцэглэхээс нь өмнө бог мал, үхэр адуу дуртай иднэ; б. навч нь унасан монс); 2. хэрэмний арьсаар хийсэн эдлэл; *хэрмэн дээл; хэрмэн малгай.*

ХЭРЭМ II хот орон, сүв боомт мэтийн газар ямар нэгэн осол аюулаас сэргийлэх хянах зэрэгт зориулж чулуу тоосгоор цогцолж эсвэл шороогоор дагтаршуулж хаалга үүд гаргаж үйлдсэн хашаа.

ХЭРЭМ III хэжиг өвчин.

ХЭРЭМЧ а м ь т а н өнгө цагаавтар, чих шилүүсний чихтэй адил өвөгтэй нэгэн зүйл шувуу.

ХЭРЭХ I 1. хүн амьтан газар газар завшаан эрж хэсэн шилжиж явах, хэсэх; **хэрэх хэсэх х о р ш.**; *энд тэнд явж хэрэх хүн;* 2. өвчин, амьтны бие махбодын энд тэнд шилжин гүйх; *хэрэх өвчин хөдлөх; ар нуруугаар хэрж өвдөөд байна;* 3. юмыг утас дээс мэтээр хөндлөн гулд ороох буюу утсаар шидмэглэн оёх; *сайн хэрж баглах хэрэгтэй; дээлийнхээ уранхайг хэрэхгүй бол улам ихдэнэ;* 4. юмыг утас дээс мэтээр холбох, торгох; **морь хэрэх** (морийг хөлөөр нь холбож уях); **үхэр хэрэх** (үхрийг хүзүүгээр нь холбох).

ХЭРЭХ II зарим амьтны бусдын эсрэт хялайж хүрцэн байх; *монгол сарлагийн хоёр бух хэрэн зогсч байв.*

ХЭРЭЭ I энд тэнд явж тоглох театр циркийн бүлэг жүжигчид; *жүжигчний хэрээ; хөгжимчний хэрээ; дуучны хэрээ.*

ХЭРЭЭ II а м ь т а н нэг зүйл махчин шувуу, урт нь 64—66 сантиметр, хүйтэн сэрүүн газар түгээмэл байдаг, ямагт хошоочноор явна, хавар эрт модны оройд өндөглөнө; *галууг дууриаж хэрээ усанд унаж үхэх* з ү й р; **хэрээний нүд** у р г а м а л (а. янз тахианы толгойд адилхан, дотоодод шид мэт үр бий, хуулж иднэ; б. иш нарийн бөгөөд олон салаа гарч ургана, үр улаан тоорцогтой мөхлөг хар, тэмээ ба бага мал дуртай иддэг нэгэн ургамал, хээр ургана).

ХЭРЭЭ III юмыг холбож уях оосор; *хашааны хэрээ дээс; морины хэрээ сур; тугалын хэрээ.*

ХЭРЭЭД монголын нэгэн овог аймгийн нэр.

ХЭРЭЭДЭС мяндас ноос хөвөн зэргээр хийсэн утас ширхгийг хэсэг хэсгээр багласан мушгиа ороолт, хэрдэс ч гэдэг.

ХЭРЭЭДЭСЛЭХ хэрээдэс үйлдэх, хэрдэслэх.

ХЭРЭЭС 1. хэрж оёх баглах олс дээс зэрэг юм; 2. мөн хэрэн оёж, боосон нь; 3. загалмай хэлбэр; **хэрээс оёдол** (загалмай мэт хэсэг хэсгээр хатгаж оёх нэг зүйл оёдол.

ХЭРЭЭСЛЭХ 1. христос шашинтны загалмайлан залбирал үйлдэх; 2. юманд хэрээс тавих.

ХЭСҮҮЛ тэнүүл, хэсч хэрэн явагч.

ХЭСҮҮЛЭХ 1. хэсэхийн үйлдүүлэх хэв; 2. дамжуулах.

ХЭСҮҮРЧ хэсэгч, тэнэмхий.

ХЭСҮҮЧЛЭХ хэрж хэсэх, тэнүүчлэх.

ХЭСХИЙМ эрэг хад, ганга гуу мэтийн эрс цавчим бөгөөд айж хэрдхийм газар; *хэсхийм хясаа; хэсхийм ганга; хэсхийм хад.*

ХЭСЭГ 1. бүхэл юмнаас тусгаарлан салгасан хувь; *энэ хайчилсан эсгийний том хэсгийг чи ав, үлдсэн бага хэсэгт нь би авна; номынхоо ихэнх хэсгийг номын санд бэлэглэв;* 2. анги бүлэг; *хэсэг байшин хашаа; хэсэг мал; хэсэг хүн; хэсэг хүн явж байв;* **хэсэг бусаг** (хэсэг хэсгээр бяцхан юм; *хэсэг бусаг арьс; хэсэг бусаг бөс);* **хэсэг хэсэг** (хэд хэдэн хэсэг, тус тус хэсэг); ☆ **хэсэг зуур** (түр зуур).

ХЭСЭГЛҮҮЛЭХ 1. хэсэглэхийн үйлдүүлэх хэв; 2. хэсэглэгдэх.

ХЭСЭГЛЭХ хэсэг болгох, тусгаар болгох, анги болгох, ангилах.

ХЭСЭГХЭН баахан хэсэг; *хэсэгхэн газар бороо орох; хэсэгхэн модтой газар.*

ХЭСЭГЧИХ хэсэглэх, хэсэг хэсэг болгох, олон хэсэг болгох.

ХЭСЭГЧЛҮҮЛЭХ хэсэгчлэхийн үйлдүүлэх хэв.

ХЭСЭГЧЛЭХ хэсэглэх.

ХЭСЭМТГИЙ хэсэмхий.

ХЭСЭМХИЙ хэсээч, тэнэмхий хүн, хэсэмтгий.

ХЭСЭХ энд тэнд хэрэн явах, хэсүүчлэх; **хэсэх тэнэх** х о р ш.; *айл хэсэх; орон хэсэх жуулчин; хэсэх хэрэх өвчин.*

ХЭСЭЭЧ хэрэггүй атлаа газар газарт хэрэн явагч хүн, хэсэмхий, хэсэмтгий.

ХЭТ (ЭН) I гал ноцоох хэрэглэл, болдыг давтаж сэнж сурвалж тогтоон хадаад шир булигаар мэтээр улавч тавьж хийнэ; *хээрийн хүн хээгүй, хэтний галд утаагүй* з ү й р; **хэт цахих, хэт хавирах** (уулыг цахиурт нааллуулан барьж хэтийг хавиран гал гаргаж ноцоох).

ХЭТ II хэтэрхий, дэндүү, давуу; *зохих хэмээс хэт гарав; санаа хэт дээр; явдал хэт оморхог; хэт шунахай; хэт завших; хэт халуун; хэт үнэлэх;* **хэт исэл** (бодисын исэлдэх хамгийн дээд хэмжээ; *устөрөгчийн хэт исэл).*

ХЭТ III 1. алс; **алс хэт** х о р ш.; *хэтийн санаа тийм байна; хэтдээ ийм болно; хэт нь хөдөө ажиллах бодолтой байдаг; хэтийн зам;* **хэтийн бодол** (алс ирээдүйг санагалзан бодох санаа бодол); **хэтийн хараа** (алсын хараа; *төлөвлөгөөг зохиохоод хэтийн хараатай байх хэрэгтэй);* **хэтдээ** (алсдаа, яваандаа, хожим; *үүнийг хадгалж бай, хэтдээ хэрэг болж болно);* 2. уг, уул; *хэт нутаг; хэтээсээ бие сайтай хүн; хэт нутаг хаа, хэрэг зориг хэнд.*

ХЭТИЙДЭХ хэтэрхий болох.

ХЭТРҮҮ хэтэрхий, даврууу; *хэтрүү зантай амьтан.*

ХЭТРҮҮЛЭХ хэтрэхийн үйлдүүлэх хэв, **хэтрэхэд** хүргүүлэх, давуулах; *төсвийг хэтрүүлэн зарах; тоо хэмжээнээс хэтрүүлэх; хэтрүүлж ярих.*

ХЭТРЭЛ хэм хэмжээнээс хэтэрсэн нь.

ХЭТРЭМГИЙ хэтрэмхий.

ХЭТРЭМХИЙ хэтэрхийгээр халдах, давамгайлах зантай; хэтрэмгий ч гэдэг; *хэтрэмхий ааштай.*

ХЭТРЭМХИЙДЭХ хэтэрхий нь дэндэх, давамгайдах.

ХЭТРЭМХИЙЛЭХ хэтрэмхий зан ааш гаргах.

ХЭТРЭХ I юмны хэвийн жишээ буюу зохих хэм, чинээ хир зэргээс давах, илүү гарах; *тоо хэмжээнээс хэтрэх; болзоо хугацаанаас хэтрэх; санал хүсэл хирээс хэтрэх.*

ХЭТРЭХ II ачаа тээш, тэрэгний арал зэргийг дээс сураар хэтрэн уях; *ачаагаа сайн хэтрэх хэрэгтэй.*

ХЭТРЭЭ 1. тэрэг хөллөх малын нурууны дээгүүр тохож тэрэгний хоёр арлыг холбох оосор; *тэрэгний хэтрээ;* 2. тэмээ малд ачих ачааг ороон уяж холбон тэгнэх оосор; *ачааны хэтрээ.*

ХЭТҮҮ 1. адуу малын арьсны дотоодод гарах цулцан яр өвчин; 2. хатуу; **хатуу хэтүү** х о р ш.; *хатуу хэтүү ажил; хатуу хэтүү мах.*

ХЭТЭВЧ юм хум агуулах жижгэвтэр сав, арьс бөс зэргээр хийнэ, хэлбэр байдал олон янз.

ХЭТЭРХИЙ юмны хир байдал, хэм хэмжээ, жишээ чинээнээс дэндүү; *хэтэрхий бага; хэтэрхий их; хэтэрхий хатуу; хэтэрхий нимгэн; хэтэрхий олон; хэтэрхий муу; хирээс хэтэрхий зан; чадлаас хэтэрхий ааш; хэтэрхий санаа; хэтэрхий шунал; хэтэрхий дур; хэтэрхий идэх; хэтэрхий унтах.*

ХЭХГЭР 1. урагш өрүүхэн цээжтэй; *хэхгэр цээжтэй эр;* 2. дээрэнгүй оморхог байдалтай; *хэхгэр зантай хүүхэд.*

ХЭХДЭГ хүн амьтны сээр нуруу хавирса өвчүүний тус хөндий цээжин бие.

ХЭХИЙХ хэхгэр зан байдал гаргах; *хэхийсэн сүрхий амьтан байна билээ.*

ХЭХРҮҮЛЭХ хэхрэхийн үйлдүүлэх хэв, байн байн хэхрэх.

ХЭХРЭГ хэхдэг.

ХЭХРЭХ ходоодноос хий огшин амаар гарах; *хоол идээд хэхрэх нь боловсон ёс бус!*

ХЭХҮС: хэхүс хэхүс б и ч и г үе үе, хүүс хүүс ч гэдэг; *хэхүс хэхүс бороо оров; хэхүс хэхүс салхи салхилав.*

ХЭХЭГЛЭХ хөхөө шувууны дуугарах.

ХЭХЭЛЗЭХ хэхгэр амьтны цээж түрж, хөнгөмсөг ааш байдал гаргах, хаахалзах ч гэдэг.

ХЭЦ I юмнаас тэлж газраас хөндий тогтоосон зэл; *морины уяаны хэц; юм өлгөх хэц; хэц татах.*

ХЭЦ II уул хадын орой нуруу буюу цавчим бэрхлэг өндөр газар; *уулын хэцэд мал гарав; хэц газар, өвд уруу явахад төвөгтэй.*

ХЭЦ III бөөгийн хэнгэрэг; *бөөгийн хэц.*

ХЭЦ IV аливаа үйл хэргийн зохисоор харьцаж тохирох тохирол; **хэц хэлхээ** х о р ш.; *хэц хэлхээ нийцэх; хэц хэлхээгий нь сайн тохируул.*

ХЭЦ V ураг төрлийн холбоо; **хэц холбоо** х о р ш.; *хэц нь бүтэн айл; хэц нь тасрах.*

ХЭЦДЭХ хэтэрхий хэц болох.

ХЭЦЛЭХ I хэц татах, хэц босгох, хэц дээр юм хум тавьж тохох; *угаасан юмаа хэцэлж хатаах хэрэгтэй.*

ХЭЦЛЭХ II хэц газраар явах, хэцэд гарах; *мал хэцэлж орхив; би хэцэлж явах дуртай.*

ХЭЦҮҮ 1. сүрхий, бэрх, хүнд; **хэцүү бэрх, хэцүү хатуу** х о р ш.; *явах зорчиход хэцүү газар; хэцүү үйл; ухахад бэрх хэцүү утга; хэцүү хүйтэн; хэцүү халуун; хэцүү амт; хэцүү үнэр; хэцүү өвчин; хэцүү эм;* 2. хэвийн жишээнээс онц гарамгай; *хэцүү мэргэн харваач; хэцүү сайн бөх; хэцүү хурдан морь;* **хэцүү хүн** (а. хашир, чадамгай, хянамгай; б. зан авир ширүүн хатуу).

ХЭЦҮҮДҮҮЛЭХ хэцүүдэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЦҮҮДЭХ хэтэрхий хэцүү болох, хүнддэх; *ажил хүнддэж хэцүүдэх; өвчин эмгэг хүнддэж хэцүүдэх.*

ХЭЦҮҮРҮҮЛЭХ хэцүүрэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЦҮҮРХҮҮЛЭХ хэцүүрхэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЦҮҮРХЭХ 1. хэцүү зан гаргах; 2. хэрэг үйлд хаширлах, бэрхшээх.

ХЭЦҮҮРЭХ улмаар хэцүү болох.

ХЭЦҮҮТГЭХ хэцүүтэхийн үйлдүүлэх хэв, улмаар хэцүү болгох.

ХЭЦҮҮТЭХ улмаар хэцүү болох.

ХЭЦҮҮШИХ хэцүүгийн шинж орох.

ХЭЦҮҮШЭЭХ айх, зүрхших, халширч бэрхшээх.

ХЭШИГ 1. хувь, тавилан; *буян хэшиг; амны хэшиг;* 2. дээдэс, өтгөс, ахмад хүний шагнах өгөх юм; *улсын хэшиг; аав эжийн хэшиг; хэшиг өгөх; хэшиг тараах; хэшиг буулгах;* **хэшиг хүртээх** (шагнал өглөг өгөх); 3. ногдол ээлж; *энэ өдөр манай хонины хэшиг тохиолдов; маргааш нөгөө айлын хэшиг ногдоно;* 4. ням гараг; *хэшиг өдөр; хэшиг гарах.*

ХЭШИГЛЭХ 1. хэшиг өгөх; 2. хэшиг ээлж тохиолдох.

ХЭШИГТ: хэшигт бялзуухай а м ь т а н бие бяцхан, толгой харавтар, эрүү цагаан, хүзүү ар хар алаг нэг зүйл, маш гоёмсог бялзуухай.

ХЭШИГТЭН өвөр монголын нэгэн овог аймгийн нэр.

ХЭЭ I 1. юм хумыг чимэглэн гоёмсоглож зурах, будах, сийлэх мэтээр зориуд гаргасан угалз цэцгийн зүйл: **хээ угалз, хээ хуар** х о р ш.; *торгоны хээ; цэцэг хээ; пүүсэн хээ;* **хээ гаргах** (торго зэрэг эд бараанд ар угалз нэхэх ба эд юманд будах, цоолборлох тових хөөх зэргээр угалз чимэг хийх); 2. юмны цэвэр үзэсгэлэнтэй, үзвэл маш дур хүрмээрий нь; **хээ гуа** х о р ш.; *хээ сайхан хээ гуа нь тохирсон эд.*

ХЭЭ II эрээ цээр, хамаа намаа; *хээгээ алдах; хээгээ барах; хээгүй явдаг амьтан.*

ХЭЭ III доожигнох, тохуурхахад гаргах аялга; *хээ хээ, яадаг билээ; хээ хээ, тэгэх байлгүй даа.*

ХЭЭВНЭГ 1. зан байдал нэг хэвээс өөрчлөгдөхгүй нэг янздаа байдаг; *хээвнэг хүн;* 2. сочоогүй, тоомсоргүй, хэнэггүй; *ичихгүй хээвнэг сууж байна.*

ХЭЭГҮЙ I хээ угалзгүй, цулгуй; *хээгүй торго; хээгүй ширээ.*

ХЭЭГҮЙ II 1. эрээ цээргүй, хамаагүй; *тэр гуай ч ёстой хээгүй хүн шүү;* 2. эдлэх хэрэглэхэд гүжирмэг тэсвэртэй; *хээгүй эдэлдэг морь; хээгүй өмсдөг хувцас.*

ХЭЭЛ I эм адгуусны хэвэл дотор тогтсон үр зулзага; *хээл олох; хээл хаях.*

ХЭЭЛ II бусдад засдаглаж хахууль болгон өгөх эд юм; **хээл хахууль** хорш.; **хээл идэх** (хээл авах); **хээл цутгах** (бусдад хахууль өгөх).

ХЭЭЛТҮҮЛЭГ хээлтүүлэх үйлийн нэр; *мал хээлтүүлэг;* **зохиомол хээлтүүлэг** (хээлтүүлэгч малын үрийг авч хээлтэгч малд зохиомол аргаар хийх хээлтүүлэг); **дур зоригийн хээлтүүлэг** (хээлтэгч хээлтүүлэгч малыг зоргонд нь нийлүүлэх нийлүүлэг); **гар хээлтүүлэг** (малыг гар аргаар нийлүүлэх нийлүүлэг).

ХЭЭЛТҮҮЛЭГЧ агтлаагүй эр мал; *хээлтэгч хээлтүүлэгч малын тохироог таарууулах.*

ХЭЭЛТҮҮЛЭХ хээлтэхийн үйлдүүлэх хэв; *бог мал хээлтүүлэх.*

ХЭЭЛТЭГЧ эм мал; *хээлтэгч мал.*

ХЭЭЛТЭЙ хээл бүхий; *хээлтэй ингэ; хээлтэй ямаа; хээлтэй үнээ; хээлтэй малыг сайн билчээрт хариулахаас гадна нэмэгдэл тэжээлээр тэжээх явдал маш чухал.*

ХЭЭЛТЭХ эм амьтанд хээл бий болох.

ХЭЭЛҮҮЛЭХ хээлэхийн үйлдүүлэх хэв.

ХЭЭЛЭХ юманд хээ гаргах.

ХЭЭНЦЭР 1. гоёмсоглон гангалахад дуртай; *хээнцэр хүн;* 2. хээ гоёмсог эд юм; *хээнцэр эд; хээнцэр сав.*

ХЭЭНЦЭРЛЭХ хээнцрээр аашлах.

ХЭЭР I айл хүнгүй алс хөдөө газар; **хээр хөдөө** хорш.; *хээрийн галуу нисэн үл хүрэх газраас хүний хүү эрдмийг өвөртөлж ирнэ* (Д. Нацагдорж); **хээрийн хөгшин** амьтан (хээр талд орших нэг зүйл шонхор шувуу): **хээрийн туулайн бөөр** ургамал (модны хальс барзгар бөгөөд навчиндаа араатай, нэг буурцагт хэд хэдэн цөмөө ургадаг ургамал, амт нь лянхуа цэцгийн үрийн амттай адил); **хээрийн үзэм** ургамал (навч цэцэг цөм үзэмтэй адил нэг зүйлийн жимс); **хээрийн цай** ургамал (цэцгийн өнгө улбар шар, иш өндөр, навч хөх бөгөөд нарийн, навчийг жигнэж эгшээн цай бүцалгаж ууна); **хээрийн галуу** (хүзүү урт, нисэхдээ зэллэж явдаг галуу); **хээрийн юм** (а. чоно; б. хөрийн юм); **хээрийн нохой** (чоно); **хээрийн шинжилгээний анги** (хөдөө орон нутагт жуулчлан явах шинжилгээний анги: *хээрийн шинжилгээний ангийн тайлан);* **хээрийн жонш** (ихэд элбэг тохиолдох нэг зүйл чулуулаг, хатуугийн зэрэг 6—6,5; өнгө цагаан, бор, ногоон янз бүр); **хээрийн шүүх** (дайн тулалдааны үед цэргийн хамт явах шүүх); **хээрийн их буу** (явуул цэргийн хамт авч явах их буу); **хээрийн дүрэм** (байлдах, дайтах арга ажиллагаанд хэрэглэх дүрэм); **хээрийн сургууль** (цэрэг дарга нарыг дайны арга ажиллагаанд бичлэн сургах нэг төрлийн хичээл; *нисэх хүчин. далайн цэргийн хавсарсан хээрийн сургууль).*

ХЭЭР II адууны зүсэм, зээрдээс баахан харавтар буюу бүдэх шаравтар зүсэмтэйгий нь, дотроо ялгал олон; *улаан хээр; хар хээр; шар хээр; бор хээр; халтар хээр;* **эх нь хээр алаг бол, хүү нь шийр алаг** (эх эцэг нь ямар бол үр садан нь мөн тийм гэх саная).

ХЭЭРЛЭХ I хээр газар зугаацаж сэлгүүцэн явах; **хээрлэн явах** (аялан явах буюу хээр зугаацан явах).

ХЭЭРЛЭХ II нас эцэслэх.

ХЭЭРЭВЧ хээр аялан явах зэрэгт хэрэглэх хээр тусгайлан хөнгөн авсаар хийсэн сав; хэрэгсэл; *хээрэвч гэр; хээрэвч тулга; хээрэвч авдар.*

ХЭЭТЭЙ хээ бүхий; *хээтэй торго; хээтэй даавуу.*

ХЭЭХЭЛЗЭХ хээхгэр юмны хөдлөх.

ХЭЭХЭН үзэмжтэйхэн, гоёхон.

ХЯВУУ амьтан нүд улбархан, хушуу харавтархан, толгой ар сүүл цөм харавтар бөгөөд цагаан чандар хольцолдсон нэг зүйл бялзуухай, бас бор хушуу ч гэнэ.

ХЯВЦАА саад тотгор, хясал боогдол; *сүрхий хявцаатай хэрэг над тохиолдоод байна.*

ХЯВЦАГ юманд харамч, харуу; *хявцаг хүн.*

ХЯВЦАГДАХ хявцахын үйлдэгдэх хэв; *би хявцагдахгүй.*

ХЯВЦАГРАХ хявцаг болох.

ХЯВЦАГТАХ хявцаг зан гаргах.

ХЯВЦАХ үйл ажилд саад тотгор болох, боох хясах;*яарч ядарч явахад намайг хявцах гэж байна уу?*

ХЯВЦУУЛАХ 1. хявцахын үйлдүүлэх хэв; 2. хявцагдах.

ХЯДААН: алаан хядаан алаан, аллага, хядлага.

ХЯДАГДАХ хядахын үйлдэгдэх хэв.

ХЯДАГЧ олноор алагч; *алан хядагч харгис фашистууд.*

ХЯДАЛДАХ хядахын үйлдэлдэх хэв.

ХЯДАЛЦАХ хядахын үйлдэлцэх хэв.

ХЯДАЛЦУУЛАХ хядалцахын үйлдүүлэх хэв.

ХЯДАХ 1. амьтныг олноор алах; **алах хядах** х о р ш.; 2. мод ургамлыг олноор огтлох, унагалах.

ХЯДЛАГА хядах үйлийн нэр; **аллага хядлага** х о р ш..

ХЯДУУЛАХ 1. хядахын үйлдүүлэх хэв; 2. хядгадах.

ХЯЗААЛАН адуу үхрийн дөрвөн настай, хонь ямааны гурван настайг, хязарлан ч гэдэг; *хязаалан насанд нь хагсааж, соёолон насанд нь сойж...* (ардын аман зохиолоос).

ХЯЗГААЛШГҮЙ б и ч г и й н хязгаарлашгүй.

ХЯЗАРЛАН хязаалан.

ХЯЗГААР 1. орон нутгийн хилийн зааг болох газар; **хил хязгаар** х о р ш.; *улсын нутгийн хязгаар;* 2. алс хол; *газрын хязгаарт бий; хязгааргүй хол нутаг;* 3. туйлын хэмжээг заахад хэрэглэнэ; **хэмжээ хязгаар** х о р ш.; *худалдан авах юмны үнийн дээд хязгаар нь нэг зуун төгрөг, доод хязгаар нь арван төгрөг;* **хязгаар үзэгдэл** (хорин найман оронтой тоо).

ХЯЗГААРГҮЙ маш их, хэмжээгүй, хэмжээлшгүй; *хязгааргүй оготргуй; хязгааргүй далай; хязгааргүй тоо; эх орондоо хязгааргүй хайртай.*

ХЯЗГААРДАХ хэтэрхий хязгаар болох.

ХЯЗГААРЛАГДАХ хязгаарлахын үйлдэгдэх хэв; *түүний хийсэн ажил үгээр хязгаарлагдах биш юм.*

ХЯЗГААРЛАГДМАЛ хязгаарлагдсан байдалтай.

ХЯЗГААРЛАХ юмыг хасах буюу хэмжээ тогтоож зогсоох; *зарим эрхийг хязгаарлах; энэ удаа зөвхөн үгээр хязгаарлавал болно.*

ХЯЗГААРЛАШГҮЙ маш үлэмж, хязгаарлаж үл болох тийм үлэмж юм, хязгаалшгүй ч гэдэг; *хязгаарлашгүй олон; хязгаарлашгүй уудам.*

ХЯЗГААРЛУУЛАХ 1. хязгаарлахын үйлдүүлэх хэв; 2. хязгаарлагдах.

ХЯЗГААРТАЙ хэм хэмжээтэй; *цэргийн тоог хязгаартай болгох.*

ХЯЛАА хүйтэн цаг агаарт цасны ширхэг бүтээд үүл болж дэгдэхгүйгээр газар буухы нь; *хялаа ихдэвэл зуд болно, хялайх ихдэвэл хэрүүл болно* з ү й р.

ХЯЛААЛАХ хялаа буух, бурганах.

ХЯЛАВ: хялав хялав хийх долгин хүний нүд байн байн урвалхийлан хөдлөх; **хялав цалав хийх** (хүний зан авир гаргаж нүд нь эргэлдэн харах).

ХЯЛАЙЛГАХ хялайхын үйлдүүлэх хэв.

ХЯЛАЙХ 1. хүнийг үл тааламжлан буруушааж нүднийхээ булангаар хөндлөн харах; *хялайсан нүдий нь хялгана хатга, ширвэсэн нүдий нь шивээ хатга* с э ц э н; 2. хүнийг дотроо муу санаж, өс хорсгол агуулах; *түүнийг нүд үзүүрлэн хялайсаар байв.*

ХЯЛАЛЗАХ байн байн хялайх, хялс хялс хийж харах.

ХЯЛАЛЗУУЛАХ хялалзахын үйлдүүлэх хэв.

ХЯЛАМХИЙХ 1. бусдыг нүдний булангаар түр үзэх, хялсхийх; *айн хэлмэж хяламхийх; долгин ааль гаргах хяламхийх;* 2. ахас дээдэс хүний энэрч өршөөн үзэх.

ХЯЛАНГАР харц муухайтай нүдтэй; **хялангартай буур** (орооны цагт маш догшин зан авир гаргадаг буур).

ХЯЛАНГАРЛАХ бусдыг нүд үзүүрлэн муухай муухай харах.

ХЯЛАР нүдний харц нь сөлөр; *хялар нүд; хялар харах.*

ХЯЛБАЛЗАХ хялмалзах.

ХЯЛБАР 1. үйл үйлдвэрийн хэцүү бэрх зүйлгүй амар хямды нь; *хийхэд хялбар ажил; үзэх судлахад хялбар зохиол;* 2. худалдаа арилжааны юмны үнэ хөнгөн бага; *хялбар үнэтэй бараа; үнэ хялбар мал.*

ХЯЛБАРЖИХ хялбар болох, хялбарших.

ХЯЛБАРЖУУЛАХ хялбаржихын үйлдүүлэх хэв.

ХЯЛБАРЛАХ хялбар болгох, хялбарчлах.

ХЯЛБАРХАН нилээд хялбар; *хялбархан арга олов.*

ХЯЛБАРЧЛАХ 1. хялбар болгох; *үйл ажлыг будлиан бэрхэд хүргүүлэхгүй хялбар болгох; эрэх ухахад хялбар болгох;* 2. хялбарыг сонгох; *ажил хэргийн хүндээс жигшин хөнгөнийг хүсэж хялбарчлах; авах хэрэглэх юмны үнэтэйг орхин хямдыг ээрч хялбарчлах.*

ХЯЛБАРЧЛУУЛАХ хялбарчлахын үйлдүүлэх хэв.

ХЯЛБАРШИХ хялбар болох, хялбарын шинж өрох.

ХЯЛБАРШУУЛАХ хялбаршихын үйлдүүлэх хэв.

ХЯЛГАНА у р г а м а л цагаалжийн аймгийн нэгэн зүйл өвс, шивээт хялгана дэрсэн толгойт хялгана гэж хоёр зүйл бий, зарим нутагт монгол өвс ногоо гэж нэрлэнэ; *хялгана хазах шүдгүй, ялаа үргээх сүүлгүй* (аман зохиол).

ХЯЛГАР нүдний цэцгий зөрүүгий нь; *хялгар нүд; хялгар харц.*

ХЯЛГАС (АН) 1. амьтны үс ноосны ширхэг, үс ноосны доторхи ширхэг бүдүүн ширүүн хатуу үс; *хялгасан үс; үхрийн хялгас;* 2. мөн хялгасаар хийсэн эд юм; *хялгасан шуудай;* **хялгасан шүүр** (хялгасыг модонд хадаж хийсэн шүүр): **хялгасан хорхой** а м ь т а н (амьтны хошгиногт үржиж ихэд загатнуулах шимэгч хорхой, хүж хорхой ч гэдэг).

ХЯЛГАСТ хялгас бүхий юм; **хялгаст мод** у р г а м а л (дал модны нэг зүйл).

ХЯЛМАА хялаа.

ХЯЛМААЛАХ хялмаа буух.

ХЯЛМАЙЛГАХ хялмайхын үйлдүүлэх хэв.

ХЯЛМАЙХ хялман байдалтай үзэгдэх, харагдах.

ХЯЛМАЛЗАХ 1. байн байн хялайх, хялбалзах; 2. морь малын явахад хөндлөн гулд сэртвэлзэх, хулмалзах.

ХЯЛМАН 1. адуу хонины зүсэм цул цагаан бөгөөд нүд цэхэр, наранд гялбаж юм үзэх нь муу; *хялман адуу; хялман үхэр;* 2. хүний үс цайм шар бөгөөд олонхи нь хөмсөггүй буюу хөмсөг маш бяцхан, нүд нь мөн гялбаж муу үзэхий нь; *хялман хүн.*

ХЯЛСХИЙХ хялайхын хоромхон үйлдэх байдал, түр зуур хялайх.

ХЯЛУУ өвөл хаврын туранхилсан доройтсон үест тэмээ ба үхрийн хэлэнд гардаг гүвдрүү өвчин.

ХЯЛУУТАХ хялуу өвчин тусах.

ХЯМГА юм хумыг хадгалах гамнах, хайрлах хичээл санаачлага; *хямга сайтай; хямга муутай.*

ХЯМГАГҮЙ хайргүй, гамгүй.

ХЯМГАДАХ хямгатай заншлыг осолдохгүй хичээж байх.

ХЯМГАДУУЛАХ хямгадахын үйлдүүлэх хэв.

ХЯМГАЛАХ хямгадах, хайрлах гамнах.

ХЯМГАЛУУЛАХ хямгалахын үйлдүүлэх хэв.

ХЯМГАТАЙ юманд гамтай.

ХЯМД 1. юмны үнэ хялбар, төсөр; **хямд хялбар** х о р ш.; *үнэ хямд худалдах;* 2. хийх үйлдэх зүйлийн хөнгөн хялбары нь; *үүнийг хийхэд харин хямд байна.*

ХЯМДАТГАХ юмны үнэ үйлтгэлийг хямд хялбар болгох.

ХЯМДАЧЛАХ 1. хямды нь сонгож ээрэх авах; 2. хялбарчлах.

ХЯМДАЧЛУУЛАХ хямдачлахын үйлдүүлэх хэв.

ХЯМДДАХ хэтэрхий хямд болох.

ХЯМДДУУЛАХ хямддахын үйлдүүлэх хэв.

ХЯМДРАХ юмны үнэ үйлтгэл хямд хялбар болох; *өргөн хэрэгцээний бараа хэд дахин хямдарчээ; за, ажил ч хямдрах тийшээ хандав.*

ХЯМДРУУЛАХ хямдрахын үйлдүүлэх хэв; *махны үнийг хямдруулах.*

ХЯМДТАХ улам хямд болох.

ХЯМДЧИЛАХ хямдыг сонгох, шилэх.

ХЯМРААН хямрах үйлийн нэр, хямралдаан.

ХЯМРАЛ 1. хямарсан нь; *хоорондын хямрал;* 2. капиталист нийгэмлэгийн эдийн засаг, төрийн үйл хэрэгт үе үе тохиолдох кризис; *эдийн засгийн хямрал.*

ХЯМРАЛГҮЙ арван их инхмэл буюу хорин оронтой тоо.

ХЯМРАЛДААН эв найрамдалгүй эсрэг тэсрэг бололцож дайн байлдаан ба зарга тэмцэл хийх зэргээр хямрах нь.

ХЯМРАЛДАХ хямрахад хүргүүлэх.

ХЯМРАЛДУУЛАХ хямралдахын үйлдүүлэх хэв.

ХЯМРАХ эсрэг тэсрэг юмны харилцан зохилдохгүй харшилдах тэмцэлдэх; ☆ **тэнгэр хямрах** (тэнгэр задарч хуйсганах); **бие хямрах** (бие тавгүй болох).

ХЯМРУУЛАХ хямрахын үйлдүүлэх хэв.

ХЯМСАЙЛГАХ хямсайхын үйлдүүлэх хэв.

ХЯМСАЙХ хямсгар байдал илрэх, ярвайж их зан гаргах.

ХЯМСАЛЗАХ байн байн хямсайх.

ХЯМСГАНАХ үргэлжлэн хямсайх.

ХЯМСГАР үл тоомсорлох байдалтай, яравгар, их зантай.

ХЯМСГАРДАХ хэтэрхий хямсгар болох.

ХЯНААЧ хуумгайдахгүй, хашир догь.

ХЯНАГЧ хянах үүрэг бүхий этгээд; **үсэг хянагч** (сонин хэвлэлийн үсэг өрлөгийн алдаа мадгийг засагч хүн); **олон нийтийн хянагч** (олон нийтийн хэв журмыг сахиж буй эсэхийг шалгагч хүн).

ХЯНАЛ 1. хянах үйлийн нэр, хяналт анхаарал; 2. үйл явдлыг болгоомжлон шинжлэх, магадлах магадлал.

ХЯНАЛГА хянах болгоомжлохы нь.

ХЯНАЛТ хянах үйлийн нэр; *хяналт тавих; хяналт гаргах; хяналттай бай; хяналтаа сулгаж болохгүй;* **хяналтын тоо** (тогтоосон тоо); **хяналтын хувь** (хэвлэл ном зэргийг хянуулахаар өгсөн хувь).

ХЯНАЛЦАХ хянахын үйлдэлцэх хэв, харилцан буюу бусдын хамт хянах.

ХЯНАМГАЙ хашир болгоомжтой; *хянамгай хүн.*

ХЯНАМГАЙЛАХ хаширлаж болгоомжлох байдал гаргах.

ХЯНАМГАЙРАХ хянамгай болох, хянамгай байдал гаргах.

ХЯНАМГАЙРХАХ хянамгай зан байдал гаргах хаширлах.

ХЯНАМЖ хяналт; **хянамж болгоомж** х о р ш; *хянамж сайтай.*

ХЯНАМЖЛАХ юмыг сайтар хянаж болгоомжлох.

ХЯНАМЖЛУУЛАХ 1. хянамжлахын үйлдүүлэх хэв; 2. хянамжлагдах.

ХЯНАХ I юмыг болгоомжилж нягтлан үзэх, санаж бодох; **хянах шалгах, хянах магадлах** х о р ш.; **хянан харгалзах** (ажиглан харгалзах); **хянан байцаах** (нягтлан байцаах); **үсэг хянах** (сонин хэвлэлийн үсэг өрлөгийн алдаа мадгийг засах).

ХЯНАХ II үс зэргийн юмнаас бяцхан танаж хасах; *үс хянах.*

ХЯНГА (Н) 1. уул хярын дээд ирмэг; *хяр хянга х о р ш.*; 2. хүний шаант чөмөгний нарийн шилбэний дээд хэсэг дэх хавтгайвтар яс; **хянган шилбэ** (хүний шаант чөмөгний нарийн үзүүрийн өмнөд этгээд, хянгар шилбэ ч гэдэг; *хянга яс);* 3. хүний хамрын ясны овгор хэсэг; *хянга хамар;* 4. амьтны бие бялдрын бялд жавхаа; *хянгатай өвгөн; хянгатай морь.*

ХЯНГАР 1. юм хум хярах огтлох өргөн хутга; *хянгар хутга;* 2. арьс шир зэргийн халим хальс мэтийг цэвэрлэх буюу элдэхэд хусах харах ирт зүйл; *элдүүрийн хянгар.*

ХЯНГАРДАХ хянгараар юмыг огтлох, хусах.

ХЯНУУЛАХ 1. хянахын үйлдүүлэх хэв; *бичсэн зүйлээ хянуулах;* 2. хянагдах.

ХЯНУУР хянамгай болгоомжтой; *хянуур хүн.*

ХЯНУУРДАХ хэтэрхий хянуур болох.

ХЯНУУРЛАХ хянуур зан гаргах.

ХЯНУУХ бусдад муу санаж дотроо хорсон занах.

ХЯНХУУЛАХ бусдад дурласхийн өдөж өө эрэх.

ХЯР I уулын орой нурууны журам; **уул хяр** х о р ш..

ХЯР II монгол эмээлийн бүүрэгний дээд ирмэг дагуулан хадахад тохируулж яс төмөрлөгөөр хийсэн зүйл; *эмээлийн хяр.*

ХЯРАА: үүрийн хяраа үүр тэмдэгрэхийн орчим үе.

ХЯРААЛАХ: үүр хяраалах үүр тэмдэгрэх үе болох.

ХЯРААЛУУЛАХ хяраалахын үйлдүүлэх хэв; *үүр хяраалуулаад хөдлөнө.*

ХЯРАМ усыг сүлж буцалгасан нэгэн зүйл унд; *цангасан хүүхдүүдэд хярам өгөөрэй.*

ХЯРАМЛАХ 1. усанд сүү холих; *ус хярамлах;* 2. юманд хярам холих; *айраг хярамлах.*

ХЯРАМЛУУЛАХ хярамлахын үйлдүүлэх хэв.

ХЯРАМЦАГ өвлийн цагт үхэр ба бог малын гэдэс дотор, цусыг гүзээнд нь хийж хөлдөөсөн нөөц; *хярамцаг идэх.*

ХЯРАМЦАГЛАХ хярамцаг хийх.

ХЯРАХ I амьтны эмээн болгоомжилж нуун бүгж хөдөлгөө чимээгүй хэвтэх; *дэрсэнд туулай хярах.*

ХЯРАХ II мах ногоо зэрэг юмыг нарийлан хэрчих зорох; *мах хярж хөшиглөх.*

ХЯРВАС түлэгдсэн юмны түлэнхийн хэншүү; **хэншүү хярвас** х о р ш.; *хярвас үнэртэж байна; хярвас хангинах.*

ХЯРВАСЛАХ хуйхалсан юмны хярвасыг арилгах цэвэрлэх; *толгой хярваслах; өвчүү хярваслах.*

ХЯРВАСЛУУЛАХ хярваслахын үйлдүүлэх хэв.

ХЯРГАГЧ хяргах этгээд, хяргадаг юм; *хонь хяргагч хүн; хяргагч машина.*

ХЯРГАДАГ үсий нь сая хяргасан нэхий; *хяргадаг нэхий.*

ХЯРГАМАЛ хяргасан юм; *хяргамал арьс.*

ХЯРГАХ малын үс ноос зэргийг хайч мэтиин зэвсгээр огтолж авах, тайрах; *хонь хяргах.*

ХЯРГУУЛАХ 1. хяргахын үйлдүүлэх хэв; 2. хяргагдах.

ХЯРГУЙ жижиг шувуудыг барьж идэх шувууны ерөнхий нэр.

ХЯРГУУЛ гургуул шувуу.

ХЯРГУУЛИГ: хяргуулиг галуу халуу мэргэний өөр нэр.

ХЯРЗАН шээх сүв, баах сүв хоёрын хоорондох газар.

ХЯРЛАХ I уулын хяраар явах.

ХЯРЛАХ II монгол эмээлд хяр хийх.

ХЯРЛУУЛАХ хярлахын үйлдүүлэх хэв.

ХЯРМАГ: хярмаг цас бяцхан ороод шуураагүй маш нимгэн цас.

ХЯРМАГЛАХ нарны төлөв үзэгдэж байвч цас хаялж орох, зарим газар хялаа буух, хялаалах ч гэдэг; *намайг ирэхэд цас бага зэрэг хярмаглаж байв.*

ХЯРС (АН) I 1. а м ь т а н үнэгний төрөл, бие жижиг, өнгө цагаавтархан, үс няг нэг зүйл амьтан; 2. мөнхүү амьтны арьсаар хийсэн эдлэл; *хярсан дээл.*

ХЯРС II төмрийн дархны хясаа, төмөрлөгийг хайлахад хэрэглэх зуух.

ХЯРУУ газарт бууж тогтсон шүүдрийн хүйтэнд царцсан цан; **цан хяруу** х о р ш.; **хяруу унах** (хяруу буух).

ХЯРУУДАХ тариа ногооны хярууд муудах, гутах; *тариа хярууда.*

ХЯРУУЛ: тэмээн хяруул а м ь т а н явган шувууны төрөл, одоо цагт бүх шувууны дотроос хамгийн том нь мөн, гүйх нь хурдан, зарим газар тэжээж өсгөх нь бий, өд нь их үнэ хүрнэ, мах ба өндгийг иднэ, тэмээлжин хяруул ч гэдэг.

ХЯРУУЛАХ хярахын үйлдүүлэх хэв.

ХЯРУУТАХ хяруу гогтох; *газар хярууташ.*

ХЯРУУТУУЛАХ хяруутахын үйлдүүлэх хэв.

ХЯСАА I мөчгө төмөрлөгийн зэрэг юмыг хайлахад нүүрс шатаах хэрэглэлийн нэр, хөөрөг тавьж шатаах салхин хийгээр шатаах хоёр зүйл байдаг, хярс ч гэдэг.

ХЯСАА II уулын халилын ирмэг, усны захын эрэгцэг мэт явах зорчиход бэрх болгоолтой, аймшигтай явц зам зэрэг газар.

ХЯСАА (Н) III а м ь т а н далай мөрөн, гол нуурт төрөх амьтан, том жижиг олон янз, заримын ясны өнгө гилгэр бөгөөд гоёмсог, юм хийвэл болно; **хясааны яс** (хясаа гэдэг амьтны хавтас яс): **хясаан оо** (хав загасны хальсыг няцчиж хийсэн будаг, өнгө цагаан, түрхэх зурахад хэрэглэнэ); **хясаа боорцог** (мах ногоо найруулан, идээ тавьж хясааны адил хийсэн боорцог, усанд чанаж иднэ).

ХЯСАА (Н) IV хясал, гацал, гацаан, боогдол; *яасан хясаантай хэрэг болов; хясаантай цаг тохиолдов.*

ХЯСАГДАХ хясахын үйлдэгдэх хэв.

ХЯСАЛ хясаа IV, боогдол.

ХЯСАХ хүссэн эрмэлзсэн зүйлийг бүтээхгүй буюу саад тавьж гацах, боох; **гацах хясах, боох хясах** х о р ш.; *чи намайг яасан ч хясаж чадахгүй; бас хясах санаатай юу, арай л юу болдоо; дуран дээр нь хясах, духан дээр нь няслах* з ү й р.

ХЯСУУЛАХ 1. хясахын үйлдүүлэх хэв; 2. хясагдах.

ХЯТАД 1. Бүгд Найрамдах Дундат Ард Улсын нэр, бас ч Нанхиад гэх нь бий; *Хятадын ард түмэн;* 2. Бүгд Найрамдах Дундад Ард Улсын үндсэн хүн амын нэр; *хятад ажилчид;* **хятад гургуул** а м ь т а н (гургуулын дотроос хамгийн том, урт нь хоёр метр, сүүл нь нэг метр гаруй урт, өнгө эрээн, өвчүүний дээд тал нь алтлаг шар, доод тал цагаан бор, жигүүр харавтар бор, нүд улаавтар нэг зүйл гургуул); **хятад шаазгай** а м ь т а н (шаазгайтай адил, хушуу хөл улаан, жигүүр хар, урт сүүлтэй, гол сүүл нь маш урт, үзүүр улаавтархан нэгэн зүйл шувуу); **хятад байцай** у р г а м а л (цагаан ногоо); **хятад гуа** у р г а м а л (амтайхан гуагаас томоохон бөгөөд түрүүнд хөхний товч мэт түнтгэртэй нэгэн зүйл гуа); **хятад өрөл** у р г а м а л (янз агалигтай адил болоод амт баахан хүчтэй, балд дарж иддэг нэг зүйл жимс): **хятад бараа** (Хятадад үйлдвэрлэсэн бараа эдлэл); **хятад давс** (энэтхэг давс); **хятад яр** (хүрэлцэхийн хор буюу тэмбүү).

ХЯТАДЖИХ 1. хятад болох; 2. хятадтай болох.

ХЯТАДРАХ хятад болох.

ХЯТАДЧИЛАХ 1. хятад дүрэм гаргаж аашлах; 2. өөр бичгийг хятад хэл дээр орчуулах.

ХЯТАДШИХ хятадын шинжтэй болох.

ХЯТАЙ адууны бүдүүн гэдэс.

ХЯТАНГАР у р г а м а л хоолой хонхор, сайр жалга газар ургадаг нэгэн зүйл ургамал, иш бүдүүн дэрсний хир, навч жижиг бөгөөд шөвгөр хавтгай, цэцэг ягаан улаан, үхрээс бусад малд хортой, харин үхэрт зохимжтой бөгөөд тарга тэнхэлд сайн гэдэг.

ХЯТРАН: хятран хараацай а м ь т а н толгой эрүү улаавтархан, бас бараан эрээн ч бий, эрүү хараацайн эрүү мэт нэг зүйл хараацай шувуу.

ХЯТРУУ I а м ь т а н гэрийн хаяа, саравчны дор үүр засдаг нэг зүйл бялзуухай.

ХЯТРУУ II нийтгэж эрчилсэн юмны эрчмийн бөөм буюу бөл цөлий нь; *утасны хятруу.*

ХЯТРУУТАХ эрчилсэн юмны эрчим бөөм, бөл цөл болох.

ХЯХАА бусдыг ямагт хяхаж явдаг заншилтай; *хяхаа хүн.*

ХЯХААХ хяхуулах, хяхахад хүргүүлэх.

ХЯХАГДАХ хяхахын үйлдэгдэх хэв.

ХЯХАЛТ хяхах үйлийн нэр.

ХЯХАХ хүнд өс атаг санаж ямагт хавчих хясах зэргээр хөнөөлхийлөх; **хяхах хавчих** х о р ш.; *хяхан хавчсаар байв.*

ХЯХНАХ 1. тэрэгний хүрд эргэх, ачаа юмны хавирснаас гарах дуу дуугарах; *тэрэг хяхнах; ачаа хяхнах;* 2. хүн амьтны хоолой сөөнгөтөж бачим дуу гарах; *хоолой хяхнах; хяхнаж дуугарах.*

ХЯХНУУЛАХ хяхнахын үйлдүүлэх хэв.

ХЯХТНАХ хяхнах чимээ гарах.

ХЯХТНУУЛАХ хяхтнахын үйлдүүлэх хэв.

ХЯХУУЛАХ 1. хяхахын үйлдүүлэх хэв; 2. хяхагдах.

Ц

Ц Ц үсэг, Ц авиа.

ЦАА: цаа буга, цаа гөрөөс бугын төрлийн нэгэн зүйл амьтан гэрийн тэжээвэр болгож эдэлнэ.

ЦААГУУР 1. холуур; *цаагуур яв! цаагуур авч хэлэлцэх; цаагуур бодол; нарнаас наагуур, надаас цаагуур* з ү й р; 2. цаад этгээд дахь; *нар, уулын цаагуур далд оров; голын цаагуур байгаа айл.*

ЦААД наад гэдгийн эсрэг утга, чанад; *голын цаад тал; манай цаад хашаа; ширээний цаад булан.*

ЦААДАХЬ цаад талд байгаа; *цаадахь айл чинь хэнийх вэ? усны цаадахь амыг юу гэдэг юм бэ?*

ЦААДТАА цаад этгээдэд, цаана; цадай ч гэдэг; *голын цаадтаа гарах; сарын цаадтаа болъё.*

ЦААЗ мөрдөн дагуулаар зааж тогтоосон дүрэм журам, хууль: **цааз хууль, хууль цааз** хорш.; **цаазны бичиг** хуучирсан (хууль дүрмийн эмхтгэл); **цаазаар аваачих** (цаазлан алах); **цаазны индэр** хуучирсан (хэрэгтэн этгээдийг алах газар).

ЦААЗАТ цааз бүхий, цаазтай; *цаазат ан; цаазат уул.*

ЦААЗЛАГДАХ цаазлахын үйлдэгдэх хэв, цаазаар алагдах.

ЦААЗЛАХ 1. зүй ёс, журам заншилд үл нийлэлцэх зүйлийг хорих, хориглох; *мөрийтэй наадмыг цаазлах;* 2. алах цаазаар аваачих.

ЦААЗЛУУЛАХ 1. цаазлахын үйлдүүлэх хэв; 2. цаазлагдах.

ЦААЗТАЙ цаазат, хориотой; *дархан цаазтай ан.*

ЦААНА 1. наана гэдгийн эсрэг утга, юмны чанд этгээд; *уулын цаана; усны цаана; гэрийн цаана;* 2. хол, цааш; *цаана бий.*

ЦААНАДАХ 1. хэтэрхий цаана болох, байвал зохих хэмээс цааш байх; *жаахан наана зогс, цаанадаад байна;* 2. цаад тал нь, цаашлахдаа; **цаанадахдаа** (хамгийн их холдохдоо).

ЦААНАДУУЛАХ цаанадахын үйлдүүлэх хэв.

ЦААНАХЬ цаана байгаа; *гэрийн цаанахь; усны цаанахь.*

ЦААРГА үйл ажилд хойрго, хойш суумтгай; *юманд тун ч цааргa хүн шүү, барагтай л бол хөдлөхгүй.*

ЦААРГАЛАХ бусдын үг санааг хүлээхгүй маргах, хойш суух, дургүйцэх; *чи битгий царгалаад байгаарай.*

ЦААРГАШИХ дургүйцэж хойш суух.

ЦААС (АН) 1. бичиг бичих, хэвлэх, зурах болон хулдах зэрэг зүйлд хэрэглэх зорилгоор тусгайлан хийсэн эдлэл; **бичгийн цаас** (бичиг бичихэд зориулж үйлдсэн цаас); **хортой цаас** (нэг хуудсанд бичиг бичих, машиндах, юм зурах тэргүүтэнд давхарлан тавьсан бусад цаасанд хуулбар гаргах будаг бүхий цаас); **цаасан дээр нэргүй, цасан дээр мөргүй** (хойч үед элдэх гавьяа зүтгэлгүй гэсэн санаа): **цаасны цавуу** (цаас наахад зориулсан цавуу); **цаасны үйлдвэр** (цаас боловсруулах үйлдвэр); 2. ярианы мөнгө төгрөг; *би түүнээс хэдэн цаас авах ёстой юм; чи над хэдэн цаас өгөөч;* 3. мөнхүү цаасаар хийсэн эдлэл; **цаасан буу** (цаасыг ягштал боож, моголцог болгоод дотор нь дарь дагтаршуулан имэрсэнд гал шатааж дуугарган наадах хэрэгсэл); **цаасан сум** (цаасаар сум хийж, хөнөөлгүй буудах сум); **цаасан шувуу** (цаасаар шувуу, эрвээхэй мэт дүрс хийж урт утсаар уяад салхинд дэгдүүлэн наадах тоглоом); **цаасан пай** (хөзөр); ☆ **цаасан малгай өмсгөх** (сайхан үгээр магтаж онгиргох.

ЦААСЛАХ юманд цаас наах; *байшин цааслах; цонх цааслах.*

ЦААСЛУУЛАХ цааслахын үйлдүүлэх хэв.

ЦААСРАХ цаас мэт болох.

ЦААТ цаа гөрөөс бүхий.

ЦААТАЙ цаат.

ЦААТАН цаа гөрөөс адуулагчид; *цаатан ардын дуу.*

ЦААХНА баахан цаана, арай цаана; *цаахна чинь бий.*

ЦААХНУУР цаахна, арай цаагуур; *арай цаахнуур яваарай.*

ЦААШ 1. наашгэдгийн эсрэг утга, чанагш; *цааш болох; цааш нь битгий хэл! цааш бүү яв! цааш харах зуур; цааш наашбүү ярь; цаашаа бай!* 2. хойш; аравнаас цааш ирээрэй; *өнөөдрөөс цааш ирэх хэрэггүй; цаашаа юу болохыг хэн мэдэх вэ;* 3. өөр; *надаас цааш хүнгүй айл; үүнээс цааш юу байдаг юм;* 4. чингэвэл чингэг, яадаг юм; *хэлбэл хэлэг цаашаа; яваад үзэг цаашаа; тогловол тоглог цаашаа; яв цаашаа;* ☆ **цааш хандах, цаашаа хандах** (цааш хөдлөх, тэсрэг болох, буруу харах); **цааш харах, цаашаа харах** (а. тэсрэг хандах, буруу харах; б. нас нөхцөх); **цааш нь харуулах** (а. чанагш харахад хүргүүлэх; б. нас нөхцөөх); **цааш хийх, цааш нь хийх** (а. нууж далдлах; б. хулгайлах).

ЦААШДАХ хэтэрхий цааш болох.

ЦААШДУУЛАХ цаашдахын үйлдүүлэх хэв.

ЦААШИД хойшид; *цаашид тавих зорилго.*

ЦААШЛАМТГАЙ даврамтгай, хэтрэмтгий, цаашламхай.

ЦААШЛАМХАЙ даврамхай, хэтрэмхий, цаашламтгай.

ЦААШЛАХ 1. улам цааш болох, хол болох; *манайх цаашилж нүүсэн; цаашлах тутам газрын гарц сайжрах юм;* 2. хүний өвчин нэмэгдэн хүндрэх, доройтох; *өдөр ирэх тутам цаашилж дордох байдалтай юм;* 3. хүний юманд хэтэрхий шунахайрах ба даварч хэтрэх; *авсан дээрээ авах гээд улам цаашлах хэрэггүй.*

ЦААШЛУУ цаашламхай зантай.

ЦААШЛУУЛАХ цаашлахын үйлдүүлэх хэв, улам цааш даврууллах; *хүүхдийг битгий цаашлуулаад бай.*

ЦААШХИ цааш байгаа, цаанахь; *цаашхий нь гарга; цаашхий нь над үзүүл.*

ЦАВ I юманд гарсан ан гав; **ан цав, гав цав** х о р ш.; **цав гарах** (ан гав гарах).

ЦАВ II лам хуврагийн хоол.

ЦАВ III хүч нэмэгдүүлэх үг: **цав цагаан** (маш цагаан); **цав цайм** (юмны өнгө маш цагааныг).

ЦАВ IV яв, яг таг; **яв цав** х о р ш.; *яв цав тохиолдов; яв цав таарчээ; дээлээ цав хийтэл бүсэлсэн байв.*

ЦАВАГ 1. монгол гэрийн дээврийн дотуур барих давхарлага; *даавуу цаваг; эсгий цаваг;* 2. юмны нимгэн халцгай буюу сиймхий цоорхой газарт давхарласан юм; *дээл хувцасны цаваг; цаваг наах; цаасаар цаваг тавь.*

ЦАВАГЛАХ дээл хувцас зэрэгт цаваг тавих; *дээлийн зах цаваглах; малгайн орой цаваглах.*

ЦАВАГЛУУЛАХ цаваглахын үйлдүүлэх хэв.

ЦАВДАХ юмыг усаар сүрчих.

ЦАВДУУЛАХ цавдахын үйлдүүлэх хэв.

ЦАВИЛАН цавилуур.

ЦАВИЛУУР малын цавь орчин торгох бяцхан олом.

ЦАВЛАХ лам хуврагийн хоол идэх.

ЦАВЛУУЛАХ цавлахын үйлдүүлэх хэв.

ЦАВТАХ юманд ан гав гарах, цав суух ч гэдэг.

ЦАВТГАХ цавтахын үйлдүүлэх хэв.

ЦАВУУ (Н) нааж наалдуулахад хэрэглэх юм; *модны цавуу; цаасны цавуу; цавуу буцалгах; цавууны сав; цавууны үнэр.*

ЦАВУУДАХ юманд цавуу түрхэж наалдуулах.

ЦАВУУДУУЛАХ цавуудахын үйлдүүлэх хэв.

ЦАВУУРАХ цавуу болох, цавуу мэт болох.

ЦАВУУШИХ цавуу мэт наалдангирах.

ЦАВУУШРАХ цавууших.

ЦАВХИЙХ юмны хийсэн бүтсэн ба байгаа байдал цэвэр үзэмжтэй, тохилог аятай байх, шавхийх ч гэнэ.

ЦАВЧААС төмөрлөг, мод зэргийн хатуу юмны цавчигдсаны ором.

ЦАВЧГАНАХ нүдээ байн байн анивхийлэх, цавчих.

ЦАВЧГАНУУЛАХ цавчганахын үйлдүүлэх хэв.

ЦАВЧДАС (АН) цавчсанаас гарсан юм; *модны цавчдас; төмрийн цавчдас.*

ЦАВЧИЛ ойд модыг огтлон гаргасан зурвас, зөрөг.

ЦАВЧИХ 1. мэс зэвсгийн ирээр юмыг цохих; *сүхээр цавчих; оолиор цавчих; мах цавчих;* 2. морь малын өмнөд хөлөөр цас, газар зэргийг цохиж малтах; 3. нүдээ анивхийлэх, ирмэх; *онгоц нүд цавчих зуур жирэвхийн өнгөрөв.*

ЦАВЧЛАХ байн байн цавчих.

ЦАВЧУУЛАХ цавчлахын үйлдүүлэх хэв.

ЦАВЧМАЛ цавчсан юм; *цавчмал чулуу; цавчмал мод.*

ЦАВЧУУЛАХ цавчихын үйлдүүлэх хэв.

ЦАВЧУУР юмыг цавчиж таслан огтлоход тохируулж хийсэн зэвсэг хэрэглэл; *цавчуур төмөр; цавчуур алх.*

ЦАВЧУУРДАХ цавчууураар цавчих.

ЦАВЬ (ЦАВИН) 1. хүний давсгийн хоёр хажуугийн хонхор зурвас газар; *нимгэн цавь;* 2. амьтны өхийн хоёр хажуугийн завсар газар; **цавины булчирхай** (цавинд байх нэг зүйл булчирхай.

ЦАВЬДАГЧ эм адгуусны цавьдар зүсэм; *цавьдагч гүү; цавьдагч байтас.*

ЦАВЬДАР адууны нэгэн зүйл зүсэм, дэл сүүл цагаавтар, шарга зээрд өнгөтэйгий нь; *цавьдар морь; цавьдар үрээ.*

ЦАГ 1. үргэлжид хөгжих материйн оршин ахуйн бодит хэлбэр; *цаг, орон зай, хөдөлгөөнөөс ангид материи байхгүй;* 2. нарны зурхайн ёсны нэгэн өдөр шөнийг 24 хуваасны нэг хувь, цагт 60 минут багтана; *одоо хэдэн цаг болж байна вэ? одоо 11 цаг болж байна;* **цаг цагт** (үе үе); **цаг нөхцөөх** (а. цагийг дэмий өнгөрүүлэх; б. ажлыг хойшлуулах); **шөнийн цаг** (шөнө, харанхуй болсон үе; *шөнийн цагаар хамаагүй сэлгүүцэж болохгүй);* **өдрийн цаг** (өдөр, гэгээтэй болсон үе; *зөвхөн өдрийн цагаар ажиллана);* 3. сарны зурхайн ёсны нэгэн өдөр шөнийг 12 хуваасны нэг хувь, цагт 8 мөч буюу 120 минут багтана; *морин цагт хөдлөх;* **цаг цагаараа байдаггүй, цахилдаг ногооноороо байдаггүй** (юм бүхэн нэг хэвээрээ байдаггүй гэсэн санаа); 4. өдөр шөнийн хувиар хэмийн хэмнүүр, сад ч гэдэг; *бугуйн цаг; энгэрийн цаг; ширээний цаг;* **сэрүүлэгтэй цаг** (зүүг тааруулан баадууг чангалбал шаардлагатай цагт хонх дуугарах цаг); **цаг үзэх** (цагийн хэм хэд болж байгааг харах); 5. жилийн дөрвөн улирал; *хавар цаг; зун цаг; намар цаг; өвөл цаг; халуун цаг; хүйтэн цаг;* **дөрвөн цаг** (хавар, зун, намар, өвөл); **цагийн гачиг** (зуд турхан, ган гачаал); ☆ **цаг уур** (тухайн үеийн агаар мандлын байдал; *цаг уурын мэдээ; цаг уурын байдал хүйтрэх төлөвтэй байна);* **цаг уурын станц** (уур амьсгал, агаар мандлын үзэгдлийг ажиглах станц); **цаг уурын судлал** (уур амьсгал болон агаар мандлын үзэгдлийг судлах ухаан); **цаг уурын хороо** (цаг уурын байдлыг судлах, мэдээлэх албан газар); 6. аливаа үйл явдлын удаан түргэний хэм; *төлөвлөгөөг цаг тухайд нь биелүүлэх;* **цагийг заах үйл үг** (уул үйлийн өнгөрсөн, одоо, ирээдүйн чухамхүү алинд болсон буюу болохыг заах үйл үг); **үйл үгийн ирээдүй цаг** (тухайн үйлийн болох ирээдүйг заасан үйл үг); **үйл үгийн өнгөрсөн цаг** (тухайн үйлийн болж өнгөрснийг заах үйл үг); **үйл үгийн одоо цаг** (тухайн үйлийн эдүгээ болж байгааг заасан үйл үг); **цаг бус, цаг бусаар** (зуурд, зуурдаар; *цаг бусаар үхэх).*

ЦАГАА I буцалгасан айраг тараг хоормог, зарим газар аарц ч гэдэг; **идээ цагаа, аарц цагаа** х о р ш.; ☆ **цагаа уух** айлаар зарцлагдаж, хүчээ өгөх).

ЦАГАА II хүн амьтны нүдэнд бий болж тогтсон цэгээн юм; *нүдний цагаа;* **цагаа унах** (өвчнөөр хар нүдний дээр цэгээн юм тогтох, бүрхэх); **цагаа тогтох** (хүн амьтны нүдэнд цагаавтар хөлх унаж тогтох); **цагаа бүрэх** (цагаа унах).

ЦАГААВТАР нилээд цагаан.

ЦАГААГЧ (ИН) эм малын цагаан зүсэм.

ЦАГААДАХ 1. хэтэрхий цагаан болох; 2. хүний хар хоргүй, нэндүү сайхан саная гаргах; 3. хүний гэм буруугаа засварлан чимэглэж ярих хэлэлцэх; *цагаадаж хэлэлцэх.*

ЦАГААДУУЛАХ цагаадахын үйлдүүлэх хэв.

ЦАГААЛАХ I цагаан сарыг ёслон өнгөрүүлэх: **шинэлэх цагаалах** х о р ш..

ЦАГААЛАХ II юмыг бартаа бэрхшээл багатай болгох буюу хялбар хөнгөн болгох; *мод цагаалах; чулуу цагаалах.*

ЦАГААЛАХ III бэлбэсэрч цагаан хувцас өмсөх.

ЦАГААЛЖ I а м ь т а н цэнгэг усанд төрөх нэг зүйл загас, том нь тохой илүү ч бий.

ЦАГААЛЖ II хялгана өвсний өөр нэр.

ЦАГААЛИГ I а м ь т а н нэгэн зүйл цэгээн гургуул.

ЦАГААЛИГ II а м ь т а н хушуу цагаавтар нэгэн зүйл хавтгалж бялзуухай.

ЦАГААЛИН I: **цагаалин жимс** у р г а м а л хушганаас амттай нэгэн зүйл жимс.

ЦАГААЛИН II: **цагаалин цэцэг** у р г а м а л өнгө цав цагаан, цэцэглэж нэн удвал маш сайхан, өвлийн сүүлээр зулгардаг нэг зүйл цэцэг.

ЦАГААЛИУЛАХ цагаалихын үйлдүүлэх хэв.

ЦАГААЛИХ 1. хүн амьтны халуунд цанган тэсж ядаж муужрах, үхэтгэх; 2. морь малын довтолж маш туйлдан ядрах.

ЦАГААЛУУЛАХ цагаалахын үйлдүүлэх хэв.

ЦАГААЛХАЙ цайлган цагаан сэтгэлтэй, атаг хар санадаггүй; *цагаалхай амьтан; цагаалхай сэтгэл.*

ЦАГААН 1. юмны цас мэт өнгө, цэгээн; **цагаан цэгээн** х о р ш.; **гурван цагаан** (өсөхөд шүд цагаан, өтлөхөд үс цагаан, үхэхэд яс цагаан); **цагаан бүрээ** (дун); **цагаан архи** (тариагаар нэрж үйлдсэн нэгэн зүйл хатуу архи); **цагаан хоолой** (мөгөөрсөн хоолой); **цагаан мөгөөрс** (хоолойн мөгөөрс); **цагаан шүүдэр** (намрын хугасын урьд буусан чийг); **цагаан цэгцгий** (хүн амьтны хар нүдний гадуурхи цэгээн хэсэг); **цагаан алт** (цагаан өнгөтэй нэгэн зүйл үнэт төмөрлөг, цахилгаан техник болон гоёл чимэглэлийн зүйлд хэрэглэнэ); **цагаан тугалга** (химийн махбод, зөөлөн, хялбар давтагдах, мөнгөн цагаан өнгөт төмөрлөг, юм гагнахад чухалчлан хэрэглэнэ), **цагаан мөнгө**

(а. бодит мөнгөөр хийсэн зоос; б. бас **ембүү**, гулдмай мөнгө); **хөнгөн цагаан** (хялбар давтагдах чанартай, мөнгөлөг цагаан өнгөтэй төмөрлөг, чанар хөнгөн); **цагаан ураг** (өндөгний дотоод цэгээн); **цагаан идээ** (малын сүү шимээр боловсруулсан зүйл зүйлийн идээний нийт нэр); **цагаан тос** (өрөмний шар тосыг ялгаж аваад үлсэн хувьд ээзгий зэргийн холио хийсэн нэгэн зүйл идээ); **цагаан будаа** (тутрага); **гэгээн цагаан өдөр** (тунгалаг сайхан өдөр, харанхуй биш цаг); **хар цагааны газар** (нүдэнд хар цагаан гэж ялгагдах хэмжээний газар); **цагаан даль** ургамал (цагаан өнгөтэй нэгэн зүйл даль); **цагаан суль** ургамал (голдуу элсэрхэг хөрстэй газар ургадаг олон наст үет ургамал, нилээд өндөр ургана, бод бог малын аль алинд тэжээл сайтай); **цагаан мэхээр** ургамал (нэг ишнээс хос бишнавч гардаг, цэцэг нь цацгийн адил, хээрийн ургамал, шар улаан хоёр зүйл бий, үндсийг иднэ): **цагаан лууван** ургамал (өнгө цагаан, амт баахан гашуун, улаан луувантай адил шиг болоод бүдүүн нэгэн зүйл идэшний ногоо); **цагаан уд** ургамал (дурс нь царс модны дурстай адилхан навч нь удны навчнаас охорхон бөгөөд өргөн нэг зүйл мод); **цагаан ногоо** (хятад **байцай**); **цагаан яргуй** ургамал (30—50 сантиметр өндөр ургадаг, олон наст өвсөрхөг ургамал, шүхэр хэлбэртэй том цагаан цэцэгтэй, ногоон байхад навч цэцгий нь үхэр дуртай иднэ); **цагаан ортууз** ургамал (чулуурхаг хөрстэй газар ургадаг сөөг ургамал, 30—40 сантиметр өндөр ургана, мал төдий л идэхгүй); **цагаан төмс** ургамал (чулуурхаг хөрстэй газар ургадаг, тод улаан цэцэгтэй ургамал, 40—60 сантиметр ургана, төмс нь цагаан өнгөтэй бөгөөд сүүнд хийж хөөрүүлэн иднэ, бас сараана ч гэдэг); **цагаан түрүү** ургамал (ойт хээрийн бүсэд ургадаг, олон наст ургамал, 15—25 сантиметр өндөр ургана, түрүү этгээдийг цагаан үс мэт зүйл бүрхэж ургана, мал төдий л идэхгүй): **цагаан цээнэ** ургамал (том цагаан цэцэгтэй нэгэн зүйл цээнэ); **цагаан харгана** ургамал (хуурайвтар бүсэд ургадаг, олон наст сөөг ургамал, малын дунд зэргийн тэжээл болохоос гадна элс тогтоох сайн чанартай); **цагаан шарилж** ургамал (20—60 сантиметр ургадаг, олон наст хагас сөөг ургамал, хээр ба ойт хээрийн өмнөд хэсгээр тохиолдоно, ногоон байхад нь мал төдий л идэхгүй); **цагаан шаваг** ургамал (голдуу цөл, заримдаг цөлийн бүсэд 10—15 сантиметр өндөр ургадаг, хагас сөөг ургамал, бүх төрлийн мал сайн иднэ); **цагаан тэрэлж** (сургарын өөр нэр); **цагаан мөөг** ургамал (идшинд хэрэглэдэг, шим сайтай нэг зүйл малгайт мөөг, тарьж ургуулбал болно); **цагаан ерхөг** ургамал (хээр, ойт хээрийн бүсэд ургадаг, тэжээлийн олон наст, үет ургамал, мал сайн иднэ): **цагаан цэцэг** ургамал (говь талын бүсэд ургадаг олон наст ургамал, өндөр нь 30—40 сантиметр, цайвар ягаан өнгийн цэцэгтэй); **цагаан галуу** амьтан (хараацайн адил, толгойдоо цагаан чандартай, сүүлийн үзүүр цагаавтархан нэгэн зүйл шувуу, загас барихдаа сайн); **цагаан гургуул** амьтан (цагаавтар зүстэй нэг зүйл гургуул шувуу); **цагаан хөмсөг** амьтан (а. шар цэцгийгээс томхон болоод бие толгой улаавтархан, үргэлжлэн дуугарах нэгэн зүйл бялзуухай; б. нүдний цэцгий улаавтархан хар, хушуу харавтар, хөмсөг цагаан, жигүүр эрээн, хөл шар нэгэн зүйл бялзуухай); **цагаан тогоруу** амьтан (өнгө цагаан, нүд цайвар шар, хушуу улаавтар, хөл улаан нэг зүйл тогоруу): **цагаан тотиг** амьтан (хүзүүндээ шар чандартай, жигүүр сүүл хар боловч үзүүр цагаан нэгэн зүйл шувуу); **цагаан могой загас** амьтан (өнгө шаравтархан, могойтой адил хайрсгүй нэг зүйл загас); **цагаан зарам** амьтан (бие моголцогхон, ам бяцхан, урт нь нэг сөөм байдаг, өөш дэгээнд хялбар ордог нэг зүйл загас); **цагаан ямаа** амьтан (урт нь 4—5 хуруугаас хэтрэхгүй, өнгө цагаавтархан болоод бараан бидэртэй хайрсгүй нэгэн зүйл жижиг загас, мөрөн голд оршино); **цагаан хорхой** амьтан (хүний хэвэлд өсөх шимэгч хорхой, өнгө цагаавтархан болоод хавтгай); **цагаан хэрэм** амьтан (үс өнгө цав цайм цэгээн нэг зүйл хэрэм, арьсаар нь хүрэм зувцга хийж өмсөнө); **цагаан үнэг** амьтан (өнгө цэгээн нэгэн зүйл үнэг); **цагаан өтөг** амьтан (мөсөн далайн захаар орших нэгэн зүйл том өтөг, өнгө цагаан, загас зэрэг далайн амьтныг барьж иднэ, арьс мах ба өөхий нь ашиглахын тулд агнана); 2. шилжсэн хэцүү бишц, амар хялбар; **цагаан үсэг** (уншихад хялбар үсэг); **цагаан толгой** (тухайн бичиг үсэгт сурах бүгд үсэг); **цагаан бичиг, цагаан хуудас** (тамга тэмдэг дараагүй албан бичиг); **цагаан газар** (уул хад, модгүй саруул тал газар буюу бартаагүй газар); **цагаан зам** (бартаа саадгүй сайхан шулуун зам); **цагаан ханиад, цагаан томуу** (аюул багатай хөнгөн ханиад өвчин); 3. шудрага, сайн, ариун үнэнч; **цагаан үйл** (ариун шудрага үйл); **цагаан санаа, цагаан сэтгэл** (бусдад хар хоргүй сайхан санаа); **арван цагаан буян** (арван хар нүглийн эсрэг арван сайн үйл); **цагаан хүн** (сайхан цайлган санаатай хүн); ☆ **цагаан бурхан, цагаан цэцэг** (их зэрэг сувилах буюу бодоо өвчний цээрлэсэн нэр); **цагаан тэмээцэх** (хүүхэд багачуудын наадах тоглоом, хэдэн хүүхэд нийлж нэг нь буур, нэгээ ботго гэж нэрлэж бусад нь ботгыг хүрээлнэ, буур нь ботгыг ба-

рих гэж тойрч зав чөлөөг эрэлхийлэн хөөж наадна); **цагаан мах** (хошгиног): **цагаан сар** (сарны зурхайн ёсны жилийн эхний сар, хаврын тэргүүн сар ч гэдэг); **цагаан сам** (буудайн гурилыг давс устай хоршин зуурч нарийн болгоод ороож ороож мушгин тосонд буцалгаж хийсэн нэг зүйл идээ). ᠴᠠᠭᠠᠨ

ЦАГААНТАН Зөвлөлт төрийн эсрэг зэвсэгт тэмцэл хийж агсан хөрөнгөтөн, газрын эздийн талынхан; *цагаантны цэрэг.* ᠴᠠᠭᠠᠨᠲᠠᠨ

ЦАГААРАХ 1. цагаан болох, цайрах; 2. цагаадах; *хэрэг цагаарах.* ᠴᠠᠭᠠᠭᠠᠷᠠᠬᠤ

ЦАГААРУУЛАХ цагаарахын үйлдүүлэх хэв. ᠴᠠᠭᠠᠭᠠᠷᠤᠤᠯᠬᠤ

ЦАГААТАХ үйл хэрэгт татагдаад холбогдолгүй болж гарах, цагаадах, цагаарах. ᠴᠠᠭᠠᠭᠠᠲᠠᠬᠤ

ЦАГААТГАХ цагаадахад хүргүүлэх, мушгигдсан хэрэг тодорхойлогдох, холбогдсон ял хэрэг холбогдлыг хэрэгсэхгүй, хэлэлцэхгүй болгох. ᠴᠠᠭᠠᠭᠠᠲᠭᠠᠬᠤ

ЦАГААТГУУЛАХ 1. цагаатгахын үйлдүүлэх хэв; 2. цагаатгагдах. ᠴᠠᠭᠠᠭᠠᠲᠭᠠᠭᠤᠯᠬᠤ

ЦАГААХАН баахан цагаан, нилээд цагаан. ᠴᠠᠭᠠᠭᠠᠨ

ЦАГААЧ (ИН) 1. хэрэн хэсч амьдрах хүн; 2. айлд гэр орнооро зарагдагсад ᠴᠠᠭᠠᠴᠠ

ЦАГААЧЛАХ цагаач болж хэрэн явах. ᠴᠠᠭᠠᠴᠢᠯᠠᠬᠤ

ЦАГААШРАХ 1. юманд сурч дадах зүгшрэх; *ном уншиж цагаашрах; морь мал эдэлгээнд цагаашрах;* 2. хүний ичих зовох, халширах бэрхшээхийг мэдэхгүй хааш яаш зан байдал гаргах. ᠴᠠᠭᠠᠰᠠᠭᠠᠰᠬᠤ

ЦАГАРИГ 1. сав суулга зэргийн юмны бүслүүр; *хувингийн цагариг; бүрхээрийн цагариг;* 2. ер нь гархи хэлбэртэй дугариг зүйл; *цагариг төмөр; цагариг гархи;* 3. юмны хүрээ болгож хийсэн дугаргий нь; *тоононы цагариг; торны цагариг.* ᠴᠠᠭᠠᠷᠢᠭ

ЦАГАРИГЛАХ 1. юм хумыг цагариг мэт болгох; 2. юманд цагариг хийх; 3. цагариг мэт болох, дугуйран хэвтэх; *могой цагариглан хэвтэв.* ᠴᠠᠭᠠᠷᠢᠭᠯᠠᠬᠤ

ЦАГАРИГЛУУЛАХ цагариглахын үйлдүүлэх хэв. ᠴᠠᠭᠠᠷᠢᠭᠯᠠᠭᠤᠯᠬᠤ

ЦАГВАР а м ь т а н цаст ууланд орших нэг зүйл барс. ᠴᠠᠭᠸᠠᠷ

ЦАГДАА 1. цагдан сэргийлэх газрын албаны сэргийлэгч; *уурын тэрэгний цагдаа; нэг цагдаагаар зам заалгаж явав;* 2. манах, хянах, байцаах зэрэг хэргийг гүйцэтгэх үүрэг бүхий хүн; *хилийн цагдаа; ойн цагдаа.* ᠴᠠᠭᠳᠠᠭᠠ

ЦАГДАХ манах, сэргийлэх; *манаж цагдах; чандлан цагдах; хориглож цагдах;* **цагдан сэргийлэх** (Бүгд Найрамдах Монгол Ард Улсад: нийтийн хэв журам, аюулгүй байдал, улсын ба ард иргэдийн хувийн өмчийг хамгаалах албан газар). ᠴᠠᠭᠳᠠᠬᠤ

ЦАГДУУЛАХ 1. цагдахын үйлдүүлэх хэв; 2. цагдагдах. ᠴᠠᠭᠳᠠᠭᠤᠯᠬᠤ

ЦАГЛАГДАХ цаглахын үйлдэгдэх хэв. ᠴᠠᠭᠯᠠᠭᠳᠠᠬᠤ

ЦАГЛАХ мэдэж ухах. ᠴᠠᠭᠯᠠᠬᠤ

ЦАГЛАШГҮЙ I хэмжээ хязгааргүй; *цаглашгүй олон амьтан.* ᠴᠠᠭᠯᠠᠰᠢᠭᠦᠢ ᠲᠤᠭᠤᠢ

ЦАГЛАШГҮЙ II жаран хоёр оронтой тоо.

ЦАГЛУУЛАХ цаглахын үйлдүүлэх хэв. ᠴᠠᠭᠯᠠᠭᠤᠯᠬᠤ

ЦАГНАХ цантах, цан хүүрэг цохих. ᠴᠠᠭᠨᠠᠬᠤ

ЦАГЦХАЙ а м ь т а н шагшин дуугарах нэг зүйл шаазгай. ᠴᠠᠭᠴᠠᠭᠠᠢ

ЦАГЦХАЙТ: цагцхайт бүргэд а м ь т а н далавч урт бөгөөд өргөн, өнгө хүрэн буурал, сүүл богино, хөгшний нь сүүл цагаан, ус орчим амьдрах тул ихэнхдээ загас идэж амьдарна. ᠴᠠᠭᠴᠠᠭᠠᠢᠲ

ЦАГЧ (ИН) цаг засдаг хийдэг хүн; *цагчин хүн; цагчны газар;* **цагч шувуу** (тахианы өөр нэр); **цагч загас** а м ь т а н (хайга загастай адилхан, мах тарган болоод амттай нэг зүйл загас); **цагч цэцэг** у р г а м а л (навч шувтан, цэцэг бяцхан болоод цагаан өнгөтэй, хялбар цэцэглэж хялбар зулгарах нэгэн зүйл цэцэг). ᠴᠠᠭᠴᠢ

ЦАГЧИГ тооны нэр, арван тэрбум . ᠴᠠᠭᠴᠢᠭ

ЦАГЧИХ шаазгай зэрэг шувууны шагшин дуугарах. ᠴᠠᠭᠴᠢᠬᠤ

ЦАГЧУУЛАХ цагчихын үйлдүүлэх хэв. ᠴᠠᠭᠴᠢᠭᠤᠯᠬᠤ

ЦАДААРАХ эд хөрөнгөндөө бардамнаж сагах, сагсуурах. ᠴᠠᠳᠠᠭᠠᠷᠠᠬᠤ

ЦАДААРХАХ хүний эд хөрөнгөндөө эрдэж бардам зан аашгарган дээрэнгүйлэх. ᠴᠠᠳᠠᠭᠠᠷᠬᠠᠬᠤ

ЦАДАХ хоол идэж ханах; **цадах ханах** х о р ш.; *цадталаа идэх; цадахад цагаан хурганы сүүл хатуу* х у у ч. ᠴᠠᠳᠠᠬᠤ

ЦАДИГ 1 түүх, намтар цэдэг ч гэдэг; **түүх цадиг, цадиг намтар** х о р ш.. ᠴᠠᠳᠢᠭ • ᠴᠠᠳᠠᠭ

ЦАДИГ II хир чинээ, хэм хэмжээ; *чи цадигаа мэдэж явах хэрэгтэй шүү, нөхөр минь!*

ЦАДИГГҮЙ 1. хир хэмжээгээ мэдэх бодохгүй хэтрүү зан ааштай; 2. хэтэрхий дүрсгүй байдалтай.

ЦАДИГГҮЙРХЭХ цадиггүй зан авир гаргах.

ЦАДИГГҮЙТЭХ цадиггүй зан байдал гаргах.

ЦАДУУЛ нүүр толгойд гарах идээ шүүстэй бяцхан яр.

ЦАДЧИН тооны нэр, арван мянжаг, арван мянган миллиард.

ЦАЙ 1. зарим ургамлын хатаасан буюу боловсруулсныг усанд буцалгаж идээшүүлэн уух ундаан; *цай хэдий шингэн боловч идээний дээж, цаас хэдий нимгэн боловч бичгийн хуудас* х у у ч; **цай барих** (хүндтэй буюу ахмад хүнд зориуд урьж цай хоол өгөх); **цай чанах** (цай буцалгаж бэлтгэх); **цай хийцлэх** (тосонд гурил будаа хуурмаглаж цайгаа өтгөрүүлэх); **сүүтэй цай** (сүүлсэн цай): **хар цай** (сүүгүй цай); **хоосон цай уух** (идэх юмгүй, дан цай уух); **хийцтэй цай** (хийцэлсэн цай); **цай уулгах** (бусдыг урьж цай өгөх); **цай хийх** (а. цай чанах, б. цай аягалах; в. цай үйлдвэрлэх); **цайны шаазан, цайны аяга** (цай уухад зориулсан шаазан, аяга); **цайны халбага** (цай уухад хэрэглэх жижиг халбага): **цайны газар** (чанасан цай олонд худалдах газар); 2. зарим ургамал навчийг ундаанд хэрэглэхээр боловсруулсны нь; **цайн идээ** (хуурай цай ба цайн ханд шим); **чулуун цай** (хатуу цай); **хатуу цай** (шахмал цай); **бай хуу цай** (байхуу ургамлаар хийсэн нэг зүйл цай, хурган цай ч гэнэ); **хээрийн цай** (а. уулын цай; б. аян явдлын хүний хөдөө замдаа уух цай): **уулын цай, өвсөн цай** (зэрлэг ургадаг, цайны өвс ургамал); **шар цай** (а. хатуу шахмал цай; б. гүйлгээнд хэрэглэж байсан цаасанд боодолтой цай; в. зарим газар, гүйлгээнд хэрэглэж байсан тусгай тэмдэгт цаас).

ЦАЙВАЛЗАХ өнгө байдал хувиран хуйсганах; *тэнгэр цайвалзах; цайвалзсан хачин зантай хүн.*

ЦАЙВАР өнгийн гүн биш цайруувтры нь; *цайвар шар; цайвар бор;* **цайвар болох** (юмны өнгө зэвхийрэн цайвгар болох).

ЦАЙВГАР юмны өнгө цайруу ба үхэтгэсэн буюу гүнгүй; *цайвгар цонхигор царайтай хүн; тэнгэрийн өнгө цайвгар болж байна, шуурч салхилж магадгүй.*

ЦАЙДАМ 1. хужир, марз, хужир марз гарах газар; *цайдам нуур; хужир цайдам;* 2. хөндий тал; *цайдам хөндий; цайдам тал.*

ЦАЙЗ 1. юманд хороолж хориглон хийсэн бяцхан хот хэрэм; **хот цайз, хэрэм цайз** х о р ш.; 2. шилтгээн.

ЦАЙЛАХ 1. бусдыг зочлон цай уулгах; 2. өглөөний зоог барих; *төлөөлөгчдийг цайлав.*

ЦАЙЛГАН цагаан санаатай, атгаггүй; *цайлган буурал эжий минь; цайлган цагаан санаагий нь.*

ЦАЙЛГАХ I цайхын үйлдүүлэх хэв, юмыг цагаан өнгөтэй болгох, цагаан өнгийг илрүүлэх; *үсээ цайлгах; мөнгө цайлгах.*

ЦАЙЛГАХ II үр тарианы аага хальсыг арилгаж цайруулах; *тариа цайлгах; будаа цайлгах.*

ЦАЙЛГАХ III бусдын эд хөрөнгийг цөлбөн хураах, хөрөнгөө бүрэлгэн үрэгдүүлэх; *хөрөнгийг хурааж цайлгах; үрэгдүүлэн цайлгах.*

ЦАЙЛЛАГА цайлах үйлийн нэр, зоог барьж дайлах дайллага; **дайллага цайллага** х о р ш.; *цайллага хийх.*

ЦАЙЛУУЛАХ цайлахын үйлдүүлэх хэв, дайлуулах.

ЦАЙР I химийн махбод, цайвар хөх өнгөтэй, хялбар давтагдах төмөрлөг.

ЦАЙР II у р г а м а л дурс ховлын дурстай адил, улаан үртэй, бут бутаар ургадаг нэгэн зүйл ургамал.

ЦАЙРАХ 1. юмны өнгө цэгээн болох, цагаарч харагдах; *үс цайрах; бороо цайрах;* 2. хүн амьтны төлжиж өнгө зүс орох; *мал таргалж цайрах; хүүхэд багачууд бойжиж цайрах;* 3. хүний юманд дадаж зүгшрэх; **цайрах цагаашрах** х о р ш.; *ном уншихад цайрах; үг хэлэхдээ цайрах;* 4. хүний хөрөнгө юм барагдаж үгүй болох; *хөрөнгө цайрах; юмаар цайрч яваа айл;* 5. ямар нэгэн үйл хэрэгт ичих зовох, халшрахыг мэдэхгүй шийдсэн байдал гарган аашлах; *ичих зовохоо ч мэдэхгүй цайрчихсан амьтан.*

ЦАЙРДАХ юманд цайр түрхэх; *толь цайрдах.*

ЦАЙРДМАЛ цайрдаж хийсэн юм; *цайрдмал дотортой түмпэн.*

ЦАЙРДУУЛАХ цайрдахын үйлдүүлэх хэв.

ЦАЙРЛАХ юмыг цайргай болгох, цайр түрхэх.

ЦАЙРЛУУЛАХ цайрлахын үйлдүүлэх хэв.

ЦАЙРУУ 1. юмны өнгө цагаавтры нь; *цайруу өнгөтэй эд;* 2. цагаалхай, цайлган; **цайруу цайлган** х о р ш.. .

ЦАЙРУУДАХ хэтэрхий цайруу болох.

ЦАЙРУУДУУЛАХ цайруудахын үйлдүүлэх хэв.

ЦАЙРУУЛАХ 1. цайрахын үйлдүүлэх хэв; 2. цайлгах, цайхад хүргүүлэх.

ЦАЙС эхнэр хүний нэг зүйл чимэглэл, алт мөнгө зэргийг хавтгайлан хоёр салаатай болгож хийгээд үсэнд хатгана.

ЦАЙСАГ цай уухдаа маш дуртай; *цайсаг хүн.*

ЦАЙСАХ цай уухыг хүсэх.

ЦАЙХ 1. юмны өнгө зүс цагаавтар болох, цайрах; *ус цайх; газар цайх; дээл хувцас цайх;* 2. хөрөнгө юм барагдаж үгүй болох, хоосрох; *хөрөнгө цайх; хоосорч цайх;* 3. ичих зовох, халшрахыг мэдэхгүй шийдсэн байдал гаргах; *бүр ч цайчсан амьтан шив даа;* ☆ **үүр цайх** (үүр хаяарч гэгээ орох; *үүр цайтал хүлээв);* **гэдэс цайх** (цагаан идээ идсээр хүсэл нь ханаж цайрах).

ЦАЛ: цал буурал хүний үс маш цагаан болсны нь; *цастынхаа давааг, цагаан буурлаараа давна, цал буурал эжийдээ ,цагтаа ирж золгоно* (ардын дуу).

ЦАЛАЙЛГАХ цалайхын үйлдүүлэх хэв.

ЦАЛАЙХ юмны дарвайн дэлгэн нээгдэх, цэлийх; *хаалгаа цалайтал дэлгэсэн байв.*

ЦАЛАМ сур дээсний нэгэн үзүүрт гогцоо гаргаж, нөгөө талыг оруулан эвхэж эргүүлдэн хаяж адуу малын толгойгоор оосорлон барих хэрэгсэл, урхи, бугуйл ч гэдэг. ɿ

ЦАЛАМДАХ цалмыг үхэр малын толгой руу хаях, цаламлах.

ЦАЛАМДУУЛАХ 1. цаламдахын үйлдүүлэх хэв; 2. цаламдагдах.

ЦАЛАМЛАХ цаламдах.

ЦАЛАНТАЙ үг явдал болхи бядуу, хийх үйлдэх юманд эв дүйгүй хүн.

ЦАЛАНТАЙЛАХ цалантайгаар аашлах.

ЦАЛГАЙ 1. сав суулга зэрэг юмны ам амсар дэлгүү ихий нь; *цалгай амтай хувин; цалгай амсартай тогоо;* 2. үйл хэрэгт хичээл зүтгэл гаргахгүй хуумгай цалгар, назгай, хайнга.

ЦАЛГАЙДАХ хэтэрхий цалгай болох.

ЦАЛГАЙРАХ цалгай болох.

ЦАЛГАЙРУУЛАХ цалгайрахын үйлдүүлэх хэв.

ЦАЛГАР I 1. нямбай биш, салан, назгай; **осол цалгар, цалгар назгай** х о р ш.; 2. хянамж сэргэмжгүй, хуумгай, цалгай; **цалгар задгай** х о р ш..

ЦАЛГАР II таваг сав зэрэг юмны амсар дэрэвгэр уужим нь; *цалгар амтай дийз.*

ЦАЛГАРАХ цалгардах.

ЦАЛГАРДАХ хэтэрхий цалгар байдал гаргах, цалгарах.

ЦАЛГАРДУУЛАХ цалгардахын үйлдүүлэх хэв; *ажлаа цалгардуулж болохгүй.*

ЦАЛГИА (Н) 1. цалгиж гарсан давлага; *усны цалгиа;* 2. усны долгионоос гарсан чимээ. ɿ

ЦАЛГИДАС цалгианд гадагш гарсан юм, халгидас ч гэдэг; *далайн цалгидас.*

ЦАЛГИЛАХ байн байн цалгих.

ЦАЛГИЛУУЛАХ цалгилахын үйлдүүлэх хэв.

ЦАЛГИУЛАХ цалгихын үйлдүүлэх хэв.

ЦАЛГИХ 1. урсгал усны давлагаа эрэг хөвөөнөөс хэтрэн долгилох; *үерийн ус цалгих;* 2. саванд агуулсан шингэн юм хөндөгдөж эсгах; *хувинтай ус цалгих; тогоотой сүү цалгих.*

ЦАЛИГ онгод; **онгод цалиг** х о р ш..

ЦАЛИН хөдөлмөрлөгсөд, дээд, тусгай мэрэгжлийн сургуульд суралцагчдад тогтмол олгох мөнгөн хөлс: **цалин хөлс** х о р ш.; **цалин тавих, цалин буух** (цалин олгох); **сул цалин** (өндөр настанд тогтмол олгох тэтгэвэр мөнгө); **бодит цалин** (цалингаар худалдан авах чадвар); **цалин нэмэгдүүлэх** (авах цалингийн хэмжээг их болгох).

ЦАЛЗГАНА а м ь т а н өнгө ногоовторхон намар сэрүүн цагт жиргэдэг нэгэн зүйл хорхой. ɿ

ЦАЛИР царил.

ЦАЛИРДАХ царилдах.

ЦАЛМАХ хэрэлдэх зодолдоход үснээс барьж үгтээх.

ЦАЛТАХ хэлэлцсэн үгээ мартаж байн байн хэлэлцэх болох.

ЦАМ шашны ёсны бүжиг; *цам үзэх;* **цам харайх; цам цамнах** (цам бүжиглэх); **цамын баг** (цам харайхад өмсөх баг).

ЦАМААН юмыг тоохгүй, голох сонгох зан аальтай; *цамаан хүнд тоогдох юм ховор.*

ЦАМААДАХ хэтэрхий цамаандах.

ЦАМААНДАХ цамаан нь дэндэх.

ЦАМААНДУУ цамаан зан байдалтай.

ЦАМААНШИХ цамаан болох, цамаан шинж гаргах.

ЦАМААРАХ цамаархах.

ЦАМААРХАГ цамаан байдалтай.

ЦАМААРХАХ цамаан зан байдал гаргах.

ЦАМААРХУУ цамаархаг, цамаандуу.

ЦАМААРХУУЛАХ цамаархахын үйлдүүлэх хэв.

ЦАМНАХ 1. цам бүжиглэх; 2. амьтны харайлан дүүлж аашлах.

ЦАМНУУЛАХ цамнахын үйлдүүлэх хэв.

ЦАМХАГ 1. байшин барилга зэрэг юмны дээр бөмбийлгөж хийсэн орой; 2. чөлөө гудамжны амыг агтлан хааж босгосон асар хаалга мэт зүйл; 3. хянах харах зэрэг зүйлд зориулж цогцлон барьсан нарийн бөгөөд өндөр барилга; *цамхаг дээр зогсох; нефть өрөмдөх цамхаг;* 4. тоононы цагаригийн дотор тэлж хийсэн мод.

ЦАМХАЙХ гэдэс дотор дүүрэх, тэлэгдэх мэтээр аягүй болох, цанхайх ч гэдэг; *дотор цамхайх; гэдэс цамхайх.*

ЦАМЦ 1. цээжээр өмсөх богино хувцас; *дотуур цамц; хөвөнтэй цамц; гадуур цамц; давхар цамц; хөх торгон цамц нь хөвөн тавиад, хөвсийгөөд байна хөө* (ардын дуу); 2. гэрийн гадуур дотуур даавуу бүрээс.

ЦАМЦЛАХ цамцтай болгох.

ЦАМЧ (ИН) 1. цам бүжиглэхдээ чадамгай хүн; 2. цам бүжиг сонирхон үзэгчид.

ЦАН I гуулиар иргүүл түвшин дотөод хөндий нимгэн хийж хоёр хэлтсийг хавсран цохиж дуугаргах хөгжмийн зэвсэг; *цан цохих; цан хавирах.*

ЦАН II хүйтний цагт ус чийг зэргээс дэгдэж гарсан уур царцаж тогтсон цас мэт зүйл; **цан хүүрэг** хорш..

ЦАНА хөлдөө уяж цасан дээгүүр гулган явах хэрэгсэл, бас модонд арьс бүрж хулдах ч бий; *цанын уралдаан; цанын бааз; цанын баг; цанын аялал;* **цана унах** (цаныг хөлд уяж явах); **цанын таяг** (цанаар явахад тулж явах хоёр таяг); ☆ **цана цэцэг** ургамал (мандарваа цэцгийн адил, цэцгийн үнэр маш сайхан, бут бутаар ургадаг нэгэн зүйл цэцэг, идэж болно).

ЦАНАЧ (ИН) цана эзэмшин хэрэглэхдээ чадамгай хүн.

ЦАНГАА цангах үйлийн нэр; **ангаа цангаа** хорш.; *амны цангаа гаргах.*

ЦАНГААХ цангахад хүрүүлэх; **ангаах цангаах** хорш..

ЦАНГАГ амьтны цангамтгайгий нь.

ЦАНГАМТГАЙ цангамхай.

ЦАНГАМХАЙ хялбархан цангадаг, цангамтгай.

ЦАНГАХ ундаасах, унд хүсэх; *ам цангаад айлд орж хүйтэн цай уув.*

ЦАНГИНАХ 1. цан зэрэг юмнаас гарах дуу; *цан цангинах; төмөр цангинах;* 2. хүний нарийн хатуу дуу хангинан гарах: **хангинах цангинах** хорш.; *цангинасан нарийн хоолойтой хүн.*

ЦАНГИНУУЛАХ цангинахын үйлдүүлэх хэв.

ЦАНГИС: цангис мод ургамал нум сум хийхэд хэрэглэдэг нэгэн зүйл мод, жимс хонгорцоглон ургадаг бөгөөд өнгө нь улаан, амт хүчтэй.

ЦАНГУУЛАХ цангахын үйлдүүлэх хэв.

ЦАНДАС уулын ар этгээдэд хүй хүйгээр ягц ургасан мод, хэрүү ч гэдэг.

ЦАННАХ цагнах.

ЦАНТАХ сахал үс, өвс мод зэргийн юман дээр цас мэт зүйл тогтох, цан тогтох.

ЦАНТУУЛАХ цантахын үйлдүүлэх хэв.

ЦАНХ I хүний цорой байн байн татаж өвдөх өвчин; **цанх татах** (цанх өвчин хөдлөх).

ЦАНХ II морины эмээл тохож, олонг татсаны дараа булгих байдал гаргаж тонгочихы нь; *энэ морийг хөдөлгөж байж мордоорой, цанх нь хөдөлж магадгүй шүү!*

ЦАНХАЙХ цамхайх.

ЦАНХИРТАХ хүний толгойн үс багаасаа цайх.

ЦАНХИРТУУЛАХ цанхиртахын үйлдүүлэх хэв.

ЦАНХЛАХ цанх хөдлөх.

ЦАНХТАЙ I цанх өвчин бүхий.

ЦАНХТАЙ II морины цанх нь хөдлөх ааштай.

ЦАНХТАХ-цанх өвчин хөдлөх, тусах.

ЦАНХУЙ: цанхуй цэцэг у р г а м а л бут бутаар зэллэн үргэлжилж ургадаг нэгэн зүйл ургамал, цэцгийн өнгө-янз бүр, цагаан өнгөтэй нь нэн үнэртэй.

ЦАР I төмөрлөгийн зүйлээр хийсэн ялтгар том таваг; *цар таваг.*

ЦАР II толины ард наалдуулан хийсэн цайр мэт зүйл; *толины цар.*

ЦАР III хаврын цасны дээгүүр нимгэн хөлдөж мэстсэний нь; цасны цар.

ЦАР IV овор хэмжээ, цараа ч гэдэг; *цар ихтэй; цар багатай.*

ЦАР V гансны толгойн дотор тогтсон үнс бохь зэрэг юм; *гансны цар.*

ЦАР VI **цар цар хийх** царцаа зэрэг амьтны дуугарах.

ЦАРАА I цар, бараа; *цараа ихтэй; цараа сайтай арьс; цараа бараатай юм.*

ЦАРАА II сумны туссан ором, цар ч гэнэ.

ЦАРАЙ 1. хүний нүүрийн өнгө зүс; **нүүр царай, царай зүс** х о р ш.; **царай барайлгах** (хүний царайн өнгө гэнт дүнсгэр бо[illegible]); **царай засрах** (нүүр биеийн өнгө ба байдал сайжирч хувилах); **царай хувьсах** (уурласан, айсан өвдсөнөөс өнгө зүс нь хэвийн байдлаас хувиран өөрчлөгдөх); **царай улайх** (а. нүүр улаан болох; б. ичих; *чамаас болж ингэж царай улайж байх уу);* **царай алдах** (а. турах, ядрах, хий моригүй болох; б. харамлах; *чи хэдэн төгрөг өгөхдөө битгий царай алдаад бай!);* **царай дарах** (алив хувцас зэрэг юм өмсөхөд хүний байдлыг гутаах; *наад малгай чинь чиний царайг бүр дарчихсан байна);* **царай орох** (хүний бие тэнхэл сайжирч засрах); **хүний царай харах, бусдын царай харах** (хүний гар харах; *өвгөн Жамц гуай бичиг үсэгт тайлагдчихаад хүний царай харахгүй ном захиа уншдаг болсон байна билээ);* **царай муутай** (а. өнгө үзэмж муутай; б. харамч байдалтай); 2. аливаа үйл ажил ба юмны байдал төлөвий нь; *энэ ажлын царай бүтэхгүй болж байна; тэнгэрийн царай муухай байна.*

ЦАРАЙЛАГ царай сайтай, үзэмж сайтай.

ЦАРАЙТ ямар нэгэн байдал төлөв нүүрт илрэхийг; *хар царайт; улаан царайт.*

ЦАРАЙТАЙ 1. аливаа төлөв байдал нүүрт илэрхий; *ер нь муухай царайтай байсан юм;* 2. царайлаг, царай сайтай.

ЦАРАЙЧЛАХ бусдыг эргадан, санаа байдалд нь зохицож явах.

ЦАРАЙЧЛУУЛАХ царайчлахын үйлдүүлэх хэв.

ЦАРАМ I хүн амьтны биед төөнөж түлэгдсэн, хайрсан зэргээс тогтсон сорви.

ЦАРАМ II хяр уулын завсрын хөндий хоолой газар ба хөвч өндөр газар мэтийн жавар сэрүүн хялбар тусах газар; **хөвч царам, хангай царам** х о р ш..

ЦАРАХ хийх үйлдэх зэрэгт болох, үл болох, орох хэрэгсэх юм хүрэлцэх эсэх зэргийг урьдаас хянан болгоомжлох; **цэнэх царах** х о р ш.; *юмыг царж бодох хэрэгтэй.*

ЦАРВАГ дээл хувцасны нөхөөс цаваг.

ЦАРВАХ гар хөлөө өргөлхийлөн аашлах.

ЦАРВАН у р г а м а л шарилжийн төрлийн нэг наст ургамал, өндөр нь 30—70 сантиметр, голдуу голын хөндий, ус чийг элбэгтэй газраар ургана, хатуу үнэртэй, зөвхөн хатсан хойно нь мал иднэ, ардын эмнэлэгт хэрэглэнэ.

ЦАРВУУ (Н) 1. хүний бугалаг орчны газар; 2. гарын хуруу, сарвуу ч гэнэ.

ЦАРГА I цасан дээгүүр явсан амьтны мөрөөр гарсан жим, чарга ч гэнэ.

ЦАРГА II харамч харуу хүн.

ЦАРГА III сумны туссан ором.

ЦАРГАДАХ харамч харуу зан гаргах.

ЦАРГАДАХ II хаврын цасны дээгүүр нимгэхэн хөлдөж мөстөх.

ЦАРГАЛАХ I цартсан цасны дээгүүр цана хэрэглэн явж ан хийх.

ЦАРГАЛАХ II харуу харамч зан гаргах.

ЦАРГАС у р г а м а л тэжээлийн нэгэн зүйл буурцагт ургамал.

ЦАРГАТАХ цасан дээгүүр зам гарах, царга тогтох, царгадах ч гэдэг.

ЦАРГИА цар цар хийсэн аягүй хатуу дуу; *царгиа дуу; царгиа хүн.*

ЦАРГИЛ дээд этгээд нарийн, доод этгээд өргөхөн тэмдэг модны адил, гурав буюу таван ширхгийг хэлхэж харшуудан цохьдог нэгэн зүйл хөгжмийн зэвсэг; *царгил хөгжим.*

ЦАРГИЛДАХ царгил хөгжим дэлдэх.

ЦАРГИУЛАХ царгихын үйлдүүлэх хэв.

ЦАРГИХ I шинэ орсон цасанд хүний нүд гялбаж өвчлөх, саргих ч гэнэ.

ЦАРГИХ II царгиа дуу гарах; *хоолой царгих.*

ЦАРГУУ буруу муу санаатай, эегүй хүн, цаарга ч гэнэ.

ЦАРДАЙЛГАХ цардайхын үйлдүүлэх хэв.

ЦАРДАЙХ амьтны хэвэл их болох, цэрдийх ч гэнэ; *өвдэс цардайх.*

ЦАРДАС цардуул.

ЦАРДАХ 1. эд бөст жонхуу ээдэн түрхэж чангаруулах; *даавуу цардах;* 2. газарт ус сүрчих; *зам цардах.*

ЦАРДМАЛ цардсан юм; *цардмал зах; цардмал даавуу; цардмал зам.*

ЦАРДУУЛ I эд бөсийг чангаруулахаар түрхэх чанамал гурил ээдэн; **цардуул хугарах** (урмас хугарах).

ЦАРДУУЛ II ус сүрчих сүрчүүл.

ЦАРДУУЛАХ цардахын үйлдүүлэх хэв.

ЦАРИЛ газар шороо, чулуу зэргийг ухах эвдэх темөр зэвсэг, цалир ч гэнэ.

ЦАРИЛДАХ юмыг царилаар ухах эвдэх, цалирдах.

ЦАРИУ бардам, давруу.

ЦАРУИДАХ цариу нь нэндэх.

ЦАРИУН 1. зан байдал дээрэнгүй, мэдэрхэг, давлиун; *цариун зантай амьтан;* 2. хэлэмгий.

ЦАРЛАХ I юманд цар тогтох; *цас царлах; ганс царлах.*

ЦАРЛАХ II үйл ажлыг хийхэд эхнээс нь дуустал бүрэн туулж гүйцэтгэх; *ажлаа царлах.*

ЦАРМАХ морь үхэр зэрэг мал адгуус өмнөх нэг хөлөөр шороо, цас, өвсийг өшиглөх, цавчлах; *морь цас цармах.*

ЦАРС (АН) у р г а м а л өндөр болоод хатуу түжир, навч урт, үртэй, дурсыг бараа будахад хэрэглэдэг нэг зүйл мод; **царсан торгомсог** (уулын хүр хорхойн үүрээр бөсийн адил нэхсэн нэгэн зүйл торго).

ЦАРТАХ юманд цар үүсч тогтох, царгатах; *цас цартах.*

ЦАРУУ юмыг царж боддог хүн; *сүрхий царуу хүн.*

ЦАРУУЛАХ царахын үйлдүүлэх хэв.

ЦАРЦАА а м ь т а н үнсэн өнгөтэй, жигүүрийн дотоод тал улаан, нисэхдээ цар цар хийж дуугардаг нэг зүйл хорхой.

ЦАРЦААХ царцахад хүрүүлэх.

ЦАРЦААХАЙ а м ь т а н жигүүр урт бөгөөд хоёр сахалтай, зургаан хөлтэй нэгэн зүйл хорхой.

ЦАРЦАЙХ цэрцийх; **царцайх цэрцийх** х о р ш..

ЦАРЦАНГИ 1. царцсан юм; *царцанги тос; царцанги өөх мах;* 2. ш и л ж с э н хал үзэж хашир таниагүй хөнгөмсөг байдалтай; *царцанги хүүхэд юу мэдэх билээ.*

ЦАРЦАНГИДАХ хэтэрхий царцанги болох.

ЦАРЦАНГИРАХ царцанги болох.

ЦАРЦАНГИТАХ царцанги байдалтай болох.

ЦАРЦАНГИШИХ царцанги шинжтэй болох

ЦАРЦАХ 1. юмны өтгөрөх, өрөмтөх; *тос царцах; өөх царцах;* 2. бага зэрэг хөлдөх; *ус царцах; газар царцах.*

ЦАРЦМАГ нимгэн хавтгайгаар царцааж хийсэн цавуу.

ЦАРЦМАЛ царцсан юм.

ЦАРЦУУ юмны царцсаны нь; *царцуу тос, царцуу өөх; царцуу хөрс.*

ЦАРЦУУДАХ нэндүү царцах.

ЦАРЦУУЛАХ царцахын үйлдүүлэх хэв.

ЦАС (АН) I жихүүн цагт агаарт усан талстууд бий болж цав цайм унгарил ширхгүүдээр буух агаарын тундас, мөнхүү тундас бууж газрын гадрагыг бүрхсэний нь; *цагаан*

цасан малгайтай, ногоон модон хүрэмтэй (Ц. Дамдинсүрэн); **цас орох, цас унах** (огторгуйгаас цас бууж ирэх); **цас хайлах** (а. нарны халуун илч зэрэгт цас гэсч ус болох; б. цасыг саванд хийж, гал түлэх зэргээр хайлуулах): **цас шуурах, цасаар шуурах** (цас, салхинд хийсч дэгдэх); **цасан шуурга** (цас хийсгэн манаруулах шуурга); **цасны ус** (цас хайлж бий болсон ус); **малын цас** (усны оронд мал идэж хүрэхүйц цас; *манай энд дөнгөж малын цас оров);* **амны цас** (хүн, хайлуулж ууж болохуйц боловч малд хүрэлцээгүй өчүүхэн бага цас); **цасан цагаан** (цав цагаан өнгөтэй); **цасан чихэр** (элсэн чихэр).

ЦАС II зэс цайр хоёр хольцонгуй хиймэл төмөрлөг; *цас хонх.*

ЦАСАРХАГ цас ихээхэн.

ЦАСАРХУУ 1. цас ихээхэн; 2. цас мэт юм.

ЦАСДАХ цас ихдэх.

ЦАСЛАХ малыг цастай газар билчээж цас идүүлэн ундлах.

ЦАСМИН у р г а м а л хээрийн нэгэн зүйл жимс, хуруу мэт хэлбэртэй, цөмийг хааж, давсанд дарж идэж болно.

ЦАСРАХ цас орох; *одоо цасарч байна.*

ЦАСРУУЛАХ цасрахын үйлдүүлэх хэв.

ЦАСТ тас ихтэй, цас бүхий.

ЦАСТАЙ цас бүхий.

ЦАСТАХ цас ихтэй болох.

ЦАСЧ: цасч тэглэй а м ь т а н өд чандар маш цагаан тэглэй шувуу.

ЦАТГАЛАН хүн амьтны идэж цадсаны нь; *би цатгалан байна; цатгалан морь; цатгалан нь өлссөний зовлонг мэдэхгүй* х у у ч.

ЦАТГАЛДАХ хэтэрхий цатгалан болох.

ЦАТГАХ цадахад хүрүүлэх, бусдад цадтал идүүлэх.

ЦАХ I түшиг тулгуур болгож тулах ацтай мод; *айргийн цах.*

ЦАХ II сая төрсөн хүүхэд; *улаан цах.*

ЦАХАР монголын нэгэн аймгийн нэр.

ЦАХДАХ цахаар тулгуурдах.

ЦАХДУУЛАХ цахдахын үйлдүүлэх хэв.

ЦАХИЛАХ I цахилгаан байн байн цахих.

ЦАХИЛАХ II амьтны ижил сүргээс цойлон гарч түргэн явах; *хонь цахилах; гөрөөс цахилах.*

ЦАХИЛГААН I 1. эрчим хүчний нэгэн зүйл, гэрэл гаргах, машина хөдөлгөх зэрэгт ашиглана: **цахилгаан гэрэл** (цахилгаан токийн хүчээр асах дэн); **сөрөх цахилгаан** (хасах цэнэгтэй цахилгаан); **эерэх цахилгаан** (нэмэх цэнэгтэй цахилгаан); **цахилгаан гагнуур** (төмрийн зүйлийг цахилгаан токийн хүчээр гагнах гагнуур); **цахилгаан дамжлага** (цахилгаан эрчим хүчийг утсаар дамжуулан хэрэгцээтэй газар хүргэх ажиллагаа); **цахилгаан задлал** (уусмалд цахилгаан ток гүйлгэж тухайн бодисыг задлах задлал); **цахилгаан соронзон** токийн гүйдлээр соронзонгийн чанар буй болгох хэрэгсэл): **цахилгаан тэрэг** (цахилгааны хүчээр явах тэрэг); **цахилгаан хөрөө** (цахилгааны хүчээр хөдөлж юм хөрөөдөх хөрөө); **цахилгаан хоовон** (цахилгааны хүчээр юм халаах хэрэгсэл); **цахилгаан хөдөлгүүр** (цахилгаан эрчим хүчийг механик хүч болгон хувиргах машина); **цахилгааны хүч** (цахилгаан токийн эрчим хүчин); **цахилгаан эмнэлэг** (цахилгаанаар эмчлэх эмнэлэг); **цахилгаан зуух** (цахилгаан токийн хүчээр дулаан гаргаж халаах зуух); **цахилгаан индүү** (цахилгааны хүчээр халах индүү); **цахилгаан данх** (цахилгааны хүчээр халж цай зэргийг буцалгах данх): **цахилгаан утас** (цахилгаан токийг дамжуулах утас); **цахилгаан чимэглэл** (цахилгаан гэрлээр чимэх чимэглэл); **цахилгаан хонх** (цахилгаан соронзонгийн хүчээр дуугарах хонх); **цахилгаан станц** (цахилгаан эрчим хүчийг гаргах үйлдвэрийн газар); **цахилгаан ток** (дамжуулагчаар гүйж буй цахилгаан цэнэг); **цахилгаан мэдээ** (а. (телеграфаар дамжуулан илгээх мэдээ; б. мөн тийм мэдээ бүхий хуудас); 2. үүлний давхрагад гялсхийн үзэгдэх гэрэл; **цахилгаан улсхийх** (үүл үзэгдэхгүй, алс хол газар цахилгааны гэрэл үзэгдэх); **цахилгаан гялсхийх** (цахилгааны гэрэл улсхийх); **цахилгаан жирэвхийх** (цахилгааны гэрэл гэнт гэнт үзэгдэх); **цахилгаан жалбалзах** (цахилгаан сэггүй цахилах); **цахилгаан цахих** (цахилгаан гялсхийх); ☆ **цахилгаан товч** (чимхүүр бариулаас барьж гүйлгэн хааж товчлох нэг зүйл төмөр товч, цамц, савны ам зэргийг хаахад хэрэглэнэ).

ЦАХИЛГААН II я р и а цахилгаан мэдээ; *цахилгаан явуулах; ирсэн цахилгаан; цахилгааны харуу.*

ЦАХИЛГААНЖИХ цахилгаантай болох, цахилгаан ихтэй болох.

ЦАХИЛГААНЖУУЛАХ цахилгаанжихын үйлдүүлэх хэв; *цахилгаанжуулах төлөвлөгөө,*

ЦАХИЛГААНТАХ морь малд тохиолдох өвчин, нүдний аньсганы дотор мөгөөрс мэт түнтгэр хатуу юм ургана.

ЦАХИЛГААНЧЛАХ 1. цахилгаан хүч хэрэглэх болох; 2. цахилгаан мэт түргэн зуур хөдлөх.

ЦАХИЛГААНЧЛУУЛАХ цахилгаанчлахын үйлдүүлэх хэв.

ЦАХИЛДАГ у р г а м а л бут бутаар ургадаг нэгэн зүйл ургамал, цэцгийн өнгө ягаавтар; *цаг цагаараа байдаггүй, цахилдаг ногоонооров байдаггүй* х у у ч.

ЦАХИЛУУЛАХ цахилахын үйлдүүлэх хэв.

ЦАХИР I хүний хумсанд гарсан жижиг цагаан дусал, хонь ч гэнэ.

ЦАХИР II цахиур; **цахир чулуу** (цахиур чулуу); ☆ **цахир дуу** (нарийн бөгөөд хахир хатуу дуу).

ЦАХИРАНЦАР цахиур, хүчилтөрөгчийн нэгдлээс бүтсэн нэг зүйл чулуулаг.

ЦАХИРМАА у р г а м а л тайга ойт хээрийн бүсэд нугатай газраар ургадаг, олон наст ургамал, төрөл зүйл олон, эмнэлэгт хэрэглэнэ, чигийрмаа ч гэдэг.

ЦАХИУЛАХ цахихын үйлдүүлэх хэв.

ЦАХИУР гал гардаг нэгэн зүйл хатуу чулуу, шил шаазан, ваарын үйлдвэрт хэрэглэнэ; **цахиур буу** (бялтгүй, цахиураар гал гаргаж буудах нэгэн зүйл буу).

ЦАХИХ 1. цахиурт уул тавьж хэтээр хавиран гал гаргах; *хэт цахих; цахиур цахих;* 2. цахилгаан гялсхийж үзэгдэх; *цахилгаан цахих.*

ЦАХЛАЙ I а м ь т а н далай нуур, мөрний эрэг дагаж оршдог шувуу, жигүүр урт бөгөөд хурц, хушуу хавчиг, хөл богино болоод дөрвөн хуруутай, өмнөх хоёр хуруунд хөвөх холбоо бий, их төлөв загас иднэ, заримдаа сүргээр байна.

ЦАХЛАЙ II үхэр малын толгойд гарч, үс нь хэсэг хэсэг халцран унадаг нэг зүйл өвчин; *цахлай гарах.*

ЦАХЛАЙТАХ цахлай гарах.

ЦАХЛАЙТУУЛАХ цахлайтахын үйлдүүлэх хэв.

ЦАХЛУУР таримал мод цэцгийг тулсан түшиг мод.

ЦАХТНАХ эмэгтэй хүний хэрцгий зан ааш гарган авирлах.

ЦАХТНУУЛАХ цахтнахын үйлдүүлэх хэв.

ЦАХТНУУР хэрцгий зантай эмэгтэй хүн.

ЦАХЧ нэгэн зүйл шаазгай шувуу.

ЦАЦ I: **цац жимс у р г а м а л амт амтайхан** болоод баахан эхүүн нэгэн зүйл жимс.

ЦАЦ II ш а ш и н нанги шаварт зай хольж сувраганы хэлбэртэй хийсэн нэг зүйл баримал.

ЦАЦААХ цацахад хүргүүлэх.

ЦАЦАГ юманд чимэг болгож утсан ширхгээр хийсэн санжлага.

ЦАЦАГДАХ цацахын үйлдэгдэх хэв.

ЦАЦАГЛАХ цацаг гаргах; *цацаглаж уях.*

ЦАЦАГЛУУЛАХ цацаглахын үйлдүүлэх хэв.

ЦАЦАГТ цацаг бий: **цацагт цэцэг у р г а м а л** (цэцгийн хэлтэс нягт нэгэн зүйл цэцэг, хүйс том бөгөөд өнгө улаан мар цагаан гурван зүйл бий, намар цэцэглэвч жихүүнд зулгарахгүй); **цацагт хяруул а м ь т а н** (толгой улаан, ар жигүүрт улбар шар өнгө хольцолдсон нэг зүйл шувуу).

ЦАЦАГТАХ цацагтай болох.

ЦАЦАЛ газар дэлхийд дээж өргөхөд зориулж хийсэн есөн нүхтэй мод; *цацал цацаж өчил өчих.*

ЦАЦАР туургагүй жижиг асар, туургатайгий нь цачир гэр гэдэг; *цацрын нуруу; цацрын багана; цацрын тулгуур.*

ЦАЦАХ I 1. сацах юмыг бутартал хаях; **хаях цацах** х о р ш.; *шороо цацах;* 2. шингэн зүйлийг сүрчих, шүрших; *ус цацах; үнэртэй ус цацах.*

ЦАЦАХ II идсэн уусан зүйл мөгөөрсөн хоолойгоор орж ханиах; *цайдаа цацах.*

ЦАЦЛАГА хуучин монгол бичгийн урагш татсан орхиц.

ЦАЦРАГ алив нэг биеэс гарсан туяа; *рентгений цацраг; цацраг туяа эмнэлэг.*

ЦАЦУУЛАХ цацахын үйлдүүлэх хэв.

ЦЕЛЛУЛОЙД целлюлозоор хийсэн хатуу эврэнцэр эд.

ЦЕЛЛЮЛОЗ эслэгээр хийсэн эд, үүгээр цаас, киноны хальс, хиймэл торго, тэсрэх зүйлийг хийнэ; *целлюлозын фабрик.*

ЦЕЛЛЮЛОИД целлулойд.

ЦЕМЕНТ зарим чулуулгуудын холимог нунтаг, энэ нь барилгын ажилд эрхэм чухал материал бөгөөд түүнийг усаар зуурч шавбал хялбар хатаж чулуу мэт хатуу болно; *цемент зуурах; цементийн завод.*

ЦЕМЕНТЛҮҮЛЭХ цементлэхийн үйлдүүлэх хэв.

ЦЕМЕНТЛЭХ цементээр шавах, цардах; *байшингийн суурь цементлэх.*

ЦЕНТНЕР 100 кг-тай тэнцэх хүндийн хэмжээ.

ЦЕХ фабрик, заводад байх салбар, алив нэг үйлдэхүүнийг боловсруулах буюу хийнэ; *цехийн мастер; цехийн хурал; гутлын цех.*

ЦИЙДҮҮЛЭХ усанд сүү тараг зэргийг хольж өнгийг цэгээн болгох.

ЦИЙДЭМ сүү зэргийг хольж цэгээн болгосон ус.

ЦИЙДЭМЛЭХ цийдэм болгох.

ЦИЙЛГЭР 1. хүн амьтны нүд цэв цэгээний нь; *цийлгэр нүдтэй хүн;* 2. юмны уужим зайтай, өнгө цэгээн, байдал нүд алдам цэлгэрий нь; *цийлгэр тал хөндий; цийлгэр өргөн ус; цийлгэр өнгөтэй тэнгэр.*

ЦИЙЛИЙЛГЭХ цийлийхийн үйлдүүлэх хэв.

ЦИЙЛИЙХ цийлгэр болох.

ЦИЙЛЭГНҮҮЛЭХ цийлэгнэхийн үйлдүүлэх хэв.

ЦИЙЛЭГНЭХ цийлгэр юмны цийлэн цийлэн хөдлөх.

ЦИЙЛЭЛЗҮҮЛЭХ цийлэлзэхийн үйлдүүлэх хэв.

ЦИЙЛЭЛЗЭХ цийлгэр юмны цийлс цийлс хөдлөх.

ЦИЙХ 1. амьтны нүд цийлгэр болох; 2. гохрох; **цийх сохрох** х о р ш.. .

ЦИРК үзэгчдэд биеийн тамирын болон сургуульгай амьтад бас алиалагчийн тоглолтыг үзүүлэх газар; *циркийн жүжигчид..*

ЦИСТЕРН шингэн зүйлийг тээхэд зориулсан том ган сав бүхий машина буюу вагон; *бензиний цистерн.*

ЦОВОО сэргэлэн авхаалжтай; **цовоо сэргэлэн** х о р ш.. .

ЦОВООДОХ цовоо нь нэндэж хэтрэх.

ЦОВООРОХ цовоо байдал орох.

ЦОВООТОХ цовоо зан гаргах.

ЦОВООШИХ цовоо шинжтэй болох.

ЦОВД I голын зах зэрэгт энд тэнд сая ургаж байгаа тармал ногоо ба бут дэрс зэргийн ёроолоор ургасан ногоо; *малд цовд ногоо идүүлэх хэрэгтэй.*

ЦОВД II арьс шир зэргийг тэлэх тэлүүр мод юм; **цовд тах** (гуталд уях зүйл).

ЦОВДЛОХ I арьс ширийг юманд тэлж хадах.

ЦОВДЛОХ II зодох жанчих.

ЦОВХОР амсар хомгор, дундууraa цулхгэр, ёроол өндөрхөн нэгэн зүйл модон аяга, зарим нутагт цогвор ч гэдэг; *үндсэн цовхор.*

ЦОВХРОХ дэгдэж дэвхцэн дүүлэх; **дэвхрэх цовхрох, харайх цовхрох** х о р ш.; *хүүхэд багачууд цовхрон наадна; хурга ишиг цовхрон гүйлдэнэ.*

ЦОВХРУУЛАХ цовхрохын үйлдүүлэх хэв.

ЦОВХЧИХ байн байн цовхрох.

ЦОВХЧУУЛАХ цовхчихын үйлдүүлэх хэв.

ЦОГ I дөл ба утаа нь барагдсан боловч галтайгаа байгаа нүүрс; **гал цог** х о р ш.. .

ЦОГ II 1. сүр, ид, жавхлан; *цог жавхлан бүрдсэн; ид цог нь бадарсан;* 2. юмны сүр жавхлантай байгаа байдлы нь; *төрийн далбаа цогтой хийсч байна; цог жавхлан нь бадарсан манай залуучууд;* **цог заль** (сүр жавхлан, цог жавхлан).

ЦОГВОР цовхор; *цогвор аяга.*

ЦОГИУЛАХ цогихын үйлдүүлэх хэв.

ЦОГИО морь малын өмнөд ба хойт хоёр хөл зэрэг зэргээр харайлан явах нэгэн зүйл явдал; *цоохор морь нь цогиотойёо хөө хөө...* (ардын дуу).

ЦОГИХ морь малын өмнөд хоёр хөл зэргээр, хойд хоёр хөл зэргээр ээлжлэн харайлан явах; *би цогиж хатирсаар яваад ирэв.*

ЦОГЛИГ: цоглиг жимс у р г а м ал янз байдал өрөлтэй адил нэгэн зүйл жимс.

ЦОГТ цог жавхлант, цог заль хий морьтой.

ЦОГТОЙ цог бүхий, цог жавхлан бүхий, цог заль хий морьтой.

ЦОГЦ 1. амьтны бие ба хүний биейн таван эрхтэн; *эрхтэн цогц;* **биейн цогц** (биейн галбир, хэлбэр; *бие цогц сайтай хүн);* 2. давхцуулан хураасан буюу давхцаж тогтсон юм; **галын цогц** (модыг дээр дээрээс нь овоолон шатаасан гал, түүдэг гал); **өвсний цогц** (өвсний бухал нуруу); **үүлний цогц** (давхарлаж гарсан үүл): **элсний цогц** (бөөгнөрөн тогтсон элс).

ЦОГЦГОР цөмцгөр, цомбогор байдалтай юм.

ЦОГЦЛОХ юмыг зэрэгцүүлж давхцуулан өрж, дэгжүүлэн хураах, тавих; *байшин савыг цогцлон барих; ном судар, бараа таваарыг байрлуулан цогцлох; хуримтлуулан цогцлох; хурааж цогцлох.*

ЦОГЦОЛБОР цогцолсон юм; 1. нэг ажлыг хийхийн тул хэд хэдэн машиныг угсран цогцолсныг нь; 2. машин механизмын нарийн төвөгтэй бүхэл бүтэн нэгэн цогц хэсэг.

ЦОГЦЛУУЛАХ цогцлохын үйлдүүлэх хэв.

ЦОГЦОЙХ цогцгор болох; *цогцойн суух.*

ЦОГЧИН шашны ёсны залбирал уншлага голлосон хурал; *цогчин хурах; цогчин дуган.*

ЦОГШИХ галын дөл утаа барагдаж улаан цог нь үлдэх; *гал цогших.*

ЦОГШУУЛАХ цогшихын үйлдүүлэх хэв.

ЦОД I шатар наадахад хүүг түлхэж шалах шалаа; *өнчин хүүгийн өрлөн цод! өрөөлтэй морины өшгөлөн шаг!*

ЦОД II хүүхэд багачууд, тарвага зэргийн амьтны цовоо маягтай дуугарахы нь.

ЦОДГОНОХ цодгор юмны үргэлжлэн хөдлөх.

ЦОДГОР хүн амьтны бие цозгор, гэдэс хэвэл цондгор; *цодгор хүүхэд.*

ЦОДЛОГДОХ цодлохын үйлдэгдэх хэв.

ЦОДЛОХ 1. шатарцаж наадахад хүүгээр шалах; 2. бусдын амыг үгээр таглах.

ЦОДЛУУЛАХ 1. цодлохын үйлдүүлэх хэв; 2. цодлогдох.

ЦОДОЙЛГОХ цодойхын үйлдүүлэх хэв.

ЦОДОЙХ цодгор болох, цодгор байдал гаргах.

ЦОДОЛЗОХ цодгор юмны байн байн хөдлөх.

ЦОЗГОНОХ цозгор юмны үргэлжлэн хөдлөх.

ЦОЗГОР хүн амьтны бие жижиг бага бөгөөд хэвлүүхэн.

ЦОЗОЙЛГОХ цозойхын үйлдүүлэх хэв.

ЦОЗОЙХ цозгор болох, цозгор зан байдал гаргах.

ЦОЗОЛЗОХ цозгор юмны байн байн хөдлөх.

ЦОЙ у р г а м а л нэг зүйл ургамал.

ЦОЙЛГОХ цойлоход хүргүүлэх.

ЦОЙЛОХ 1. олон амьтны дундаас тасран гарч онцгой явах; *хонь цойлох; морь цойлох;* 2. харвасан, буудсан сум зэрэг зүйл газар тусч дахин дээш ойн одох; *сум цойлох.*

ЦОЙЛУУЛАХ цойлохын үйлдүүлэх хэв.

ЦОЙРОН I сая төрсөн ботго.

ЦОЙРОН II: **цойрон цуцал** а м ь т а н хүшуу урт, ар шаравтархан, толгойдоо сэвхтэй, хөөнийхөө доод талд урт чандартай, хүзүү тэмээний адил гагагар нэг зүйл бялзуухай.

ЦОЙХ цойлох, цойж гарах.

ЦОЙЦГОНОХ цойцгор, цойцон юмны үргэлжлэн хөдлөх.

ЦОЙЦГОР 1. цомцгор, цомбогор; 2. цойцон; *цойцгор хөлтэй ширээ; цойцгор хөлтэй морь.*

ЦОЙЦОЙЛГОХ цойцойход хүргүүлэх.

ЦОЙЦОЙХ цойцгор, цойцон болох; *цойцойж суух.*

ЦОЙЦОЛЗОХ цойцгор юмны байн байн хөдлөх.

ЦОЙЦОН хэлбэр байдал хэвийн биш болсон юм; *цойцон аяга; цойцон хөлтэй.*

ЦОЙЦРОХ цойцгор болох; *цойцорч явах.*

ЦОЛ I 1. хүмүүсийн албан тушаал, мэрэгжлийн зэрэг дэсийг ялгахын тулд албан ёсоор олгосон эрхэмлэн хүндэтгэх нэр; *хурандаа цол; цэргийн цол; нэгдүгээр зэргийн шатарчин цол авах;* 2. гавьяа байгуулагсдад албан ёсоор олгох хүндэт алдар; *БНМА Улсын хөдөлмөрийн баатар цол олгох; БНМА Улсын баатар*

цол; Ардын жүжигчин цол авах; БНМА Улсын гавьяат зоотехникч цолоор шагнагдав; цол шагнах; 3. магтаал; *бөхийн цол; морины цол дуудах; дайснаа дарж дархан цолоо олж, өшөөтнөө дарж өргөн цолоо олж...* (үлгэрээс); 4. хоч; **нэр цол** х о р ш.; *нэр цол өгөх.*

ЦОЛ II: цол цол хийх савтай шингэн юмны зайлагдаж хөдлөх чимээ сонсдох; *хөхүүртэй айраг цол цол хийн дуугарч байв.*

ЦОЛБОН: цолбон тайга а м ь т а н сахлаг сайхан үстэй, үзэмжтэй сайн нохой.

ЦОЛГИЛОХ дэмий өрсөлдөн хэлэлцэх.

ЦОЛГИЛУУЛАХ цолгилохын үйлдүүлэх хэв.

ЦОЛГИО задгай амтай, бусдаас түрүүлж өрсөлдөн ярих хэлэлцэх зантайгий нь; *цолгио хүн.*

ЦОЛГИУЛАХ цолгихын үйлдүүлэх хэв.

ЦОЛГИХ загас зэргийн амьтан усны дотроос дээш үсрэн гарах; **ойх цолгих** х о р ш..

ЦОЛЛОХ хүчит бөх, хурдан морь зэрэгт олгосон цолыг олны дунд өндөр дуугаар хэлэх ба цол олгох; *бөх цоллох; морь цоллох.*

ЦОЛЛОГДОХ цоллохын үйлдэгдэх хэв.

ЦОЛЛУУЛАХ 1. цоллохын үйлдүүлэх хэв; 2. цоллогдох.

ЦОЛМОН з у р х а й үүрээр зүүн зүгт, үдэш баруун зүгт үзэгдэх хамгийн гэрэлтэй од, Алтан од ч гэнэ; *чухамхүү сэтгэл хэвээрээ байвал, Цолмон гаргаад мордоно доо хөө* (ардын дуу); **үүрийн цолмон** (Алтан одны үүрээр үзэгдэхийг); **үдшийн цолмон** (Алтан одны үдэш үзэгдэхийг).

ЦОЛТ цол бүхий.

ЦОЛТОЙ цол бүхий; *улсын баатар цолтой; арслан цолтой бөх; дэслэгч цолтой.*

ЦОЛХИЙХ пол хийх, юмны усан дотор живж ороход гарах чимээ сонсдох.

ЦОЛЦГОНОХ цолцгор юмны үргэлжлэн хөдлөх.

ЦОЛЦГОР цулцгар.

ЦОЛЦОН цулцан.

ЦОЛЦОНТОХ цолцонтой болох, цолцон гарах.

ЦОЛЦОНТУУЛАХ цолцонтохын үйлдүүлэх хэв.

ЦОЛЧГОНОХ саймсрах зан байдал гаргах, долдгонох.

ЦОЛЧГОНУУЛАХ цолчгонохын үйлдүүлэх хэв.

ЦОЛЧДОХ багадах, томоогүйдэх.

ЦОЛЧОО 1. хэл султай; 2. дэмий яримтгай.

ЦОЛЧРОО хэл нь цолчирдог хүн.

ЦОЛЧРОХ ярих хэлэлцэхэд хэл нь ээдрэх.

ЦОЛЧРУУЛАХ цолчрохын үйлдүүлэх хэв.

ЦОЛЬД 1. хэсэг хэсэг устай, хэсэг хэсэг хуурай газар; *цольд газар;* 2. тариг хадаж авахад тариалангийн зах сэжүүрт хадгдаагүй үлсэн газар; *цольд үлдээлгүй хадах хэрэгтэй;* 3. эрдэм чадал бусдаас онц тасархай болсон хүн; *цольд хүн.*

ЦОМ юмны эмх цэгцтэй, хураамжтай аятайгий нь; *юмаа цом байлга.*

ЦОМБОГОР 1. аяга сав зэргийн цомбон авсаары нь; *цомбогор шаазан;* 2. цом авсаар юм; *цомбогор боодолтой юм.*

ЦОМБОЙЛГОХ цомбойхын үйлдүүлэх хэв, цомбогор болгох.

ЦОМБОЙХ цомбогор болох.

ЦОМБОН аяга сав зэргийн цомбогор хэлбэртэйгий нь; *цомбон аяга; цомбон тогоо; цомбон туурай; цомбон туурайтай хүрэн нь, цохолсон хар алхаатай* (ардын дуу).

ЦОМОГ өвс шарилж мэтийн юмыг уртаар овоолон тавихы нь.

ЦОМОГЛОХ өвс мод зэргийн юмыг хольцолдуулан овоолж цогцлох; *өвс цомоглох; мод цомоглох.*

ЦОМОГЛУУЛАХ цомоглохын үйлдүүлэх хэв.

ЦОМОО амсар этгээд хумигар, ёроол гүн бяцхан аяга.

ЦОМОРЛИГ 1. цэцгийн дэлгэж цэцэглээгүй бөөмий нь; *цэцгийн цоморлиг;* 2. амуу тарианы үр мөхлөгүүд; *тарианы цоморлиг;* 3. ном зохиолын түүвэрлэж эмхтгэн нэгэн бөөм болгосны нь; *зохиолын цоморлиг.*

ЦОМОРЛИГЛОХ цоморлиг болгох.

ЦОМОРЛИГТОХ цэцгийн цоморлиг ургаж гарах,

ЦОМОРЛИГТУУЛАХ цоморлигтохын үйлдүүлэх хэв.

ЦОМРОХ цом болох.

ЦОМРУУЛАХ цомрохын үйлдүүлэх хэв.

ЦОМСГОХ цомтгох.

ЦОМСОХ цомтох.

ЦОМТГОХ юмыг эмхтэй хураамжтай цом болгох.

ЦОМТОХ улмаар цом болох.

ЦОМХДОХ хэтэрхий цом болох.

ЦОМХОН цом, аятайхан, авсаархан, багахан.

ЦОМХОТГОХ улмаар цом болгох.

ЦОМХРОХ цомхдох, эмхрэх; **эмхрэх цомхрох** х о р ш..

ЦОМХТОХ улмаар цомхон болох.

ЦОМЦГОР цомбогор, цэмцгэр юм; *цомцгор цагаан гэр; цомцгор хувин.*

ЦОМЦГОРДОХ хэтэрхий цомцгор болох.

ЦОМЦОЙЛГОХ цомцойхын үйлдүүлэх хэв.

ЦОМЦОЙХ цомцгор болох; *цомцойж суух.*

ЦОМЦРИУЛАХ цомцрихын үйлдүүлэх хэв.

ЦОМЦРИХ хүн амьтны сахлаг өвсний дотуур зүдэн явах.

ЦОН улаан буюу улбар шар **өнгөтэй** нэг зүйл эрдэнийн чулуу, чун ч гэдэг.

ЦОНГОР хонхор; **онгор цонгор** х о р ш..

ЦОНГОРХОЙ: онгорхой цонгорхой баахан хонхор цонгор.

ЦОНДГОР амьтны гэдэс хэвэл **зэргийн** юмны гадагш түмбийсний нь; *цондгор гэдэс.*

ЦОНДОГ гэрийн өрхийг дэндийлэх мод.

ЦОНДОГЛОХ цондгоор өрхийг дэндийлгэн тулах.

ЦОНДОЙЛГОХ цондойхын үйлдүүлэх хэв.

ЦОНДОЙХ цондгор болох; *гэдэс нь цондойх.*

ЦОНДОН I цондгор; *цондон гэдэстэй хүүхэд.*

ЦОНДОН II тавилан, ёр, бэлэгдэл; *сайны цондон; муугийн цондон.*

ЦОНДУУЛ хар тогшуурга шувуу.

ЦОНОГ хулгана зурам зэрэг жижиг амьтны нүх.

ЦОНОГЛОХ жижиг амьтны нүх малтах.

ЦОНООХ цоноход хүрүүлэх.

ЦОНОХ халуун илчид эзгдэж шатах шахам болох; *галд цонох; наранд цонох.*

ЦОНХ (ОН) байшин барилга зэрэгт **гэрэл** оруулахаар хийсэн гэгээвч; *дан цонх; давхар цонх; цонхны салхивч; цонхны шил; цонхны жааз; цонхны хүрээ;* **цонхны ялуу** (цонхны яс модны хөндлөний нь); **цонхны хацар** (цонхны яс модны гулд этгээдий нь); **цонхны мөгөө** цонхны янз).

ЦОНХИГОР юмны царай өнгө хунхгүй цайвгар болсны нь; *цонхигор царайтай хүн; газрын өнгө цохигор болжээ.*

ЦОНХИЙЛГОХ цонхийход хүргүүлэх.

ЦОНХИЙХ өнгө царай цонхигор болох.

ЦОНХИОЛ сүрхий гүн тунгалаг ус.

ЦОНХИРТОХ цонхигор байдалтай харагдах.

ЦОНХОР онхор хонхор; **онхор цонхор, хонхор цонхор** х о р ш..

ЦОНХОРХОЙ 1. онгорхой; **онгорхой цонгорхой х о р ш.**: 2. **хонхорхой; хонхорхой цонхорхой** х о р ш..

ЦОО I нэвт; *цоо цохих; цоо харвах; цоо татах.*

ЦОО II хуучраагүй; **цоо шинэ** (шив шинэ, тун шинэ, бүр шинэ); **цоо бүтэн** (эд хэрэглэгдэхүүний гэмтэл **сэвгүй** бүрэн бүтэн хэвээр байгаа).

ЦОО III: **цоо начин а м ь т а н** янз начинтай адил, жигүүр урт, шувуу барих жигүүрээр дэлдэх нь маш хурдан нэгэн зүйл шувуу.

ЦООВОР поваарь.

ЦООГ: алаг цоог энд тэнд, адил тэгшгүй; *алаг цоог ногоотой бөлж байна; цас алаг цоог цоохортож байна.*

ЦООГЛОХ бөөгнөрөн цугларах; *цооглон зогсох; овоорон цооглох.*

ЦООГЛУУЛАХ цооглохын үйлдүүлэх хэв.

ЦООГОНДОЙ амьтан мийтэй адил болоод өнгө барааи, дагуу бидэртэй, мийн намын нэг зүйл амьтан.

ЦООГЧЛОХ алагчлан ялгаварлаж үзэх; **алагчлах цоогчлох** хор ш.; *цоогчлон үзэх; цоогчлон ялгах.*

ЦООГЧЛУУЛАХ 1. цоогчлохын үйлдүүлэх хэв; 2. цоогчлогдох.

ЦООЖ орон байшин, сав суулганы үүд хаалга, ам амсрыг бэхлэн торгож оньслох хэрэгсэл; **цоож цуурга** хор ш.; *цоож түлхүүрээ аваарай;* **цоожны хайрцаг** (монгол цоожны өргөс орох их бие); **цоожны өргөс, цоожны сэрвээ** (монгол цоожны хайрцагт орж түлхүүрээр гарах оньс).

ЦООЖЛОГДОХ цоожлохын үйлдэгдэх хэв.

ЦООЖЛОХ юмыг цоож торгож оньслох; *хаалга үүдээ сайн цоожлох хэрэгтэй.*

ЦООЖЛУУЛАХ 1. цоожлохын үйлдүүлэх хэв; 2. цоожлогдох.

ЦООЖТОЙ цоож бүхий, цоожоор оньсолсны нь; *намайг очиход гэр чинь цоожтой байна билээ.*

ЦООЛБОР 1. юманд цоолж гаргасан хээ угалз, янз чимэг; *цоолбор угалзтай гутал; цоолбор сийлбэртэй ширээ;* 2. цоолох багаж; *цоолборын хутга.*

ЦООЛБОРЛОХ юманд янз хээ угалз цоолж гаргах.

ЦООЛБОРЛУУЛАХ цоолборлохын үйлдүүлэх хэв.

ЦООЛГО (Н) мөсийг цоолон ус авах буюу загас барих газар; *мөсний цоолго.*

ЦООЛГОЛОХ цоолго хийх.

ЦООЛОХ юманд нэвт нүх гаргах.

ЦООЛТУУР 1. цоолж нүхлэх багаж; 2. мод зэрэг юмыг сийлэн ухаж цоолох хутга, цоолбор ч гэнэ.

ЦООЛТУУРДАХ цоолтуураар цохиж цоолох.

ЦООЛТУУРЛАХ цоолтуур, цоолбор багажаар цоолох.

ЦООЛУУЛАХ цоолохын үйлдүүлэх хэв.

ЦООНОГ 1. мэрэгч амьтны орж орших эгц нүх; 2. эгц доош орсон нүх; 3. эгц доош өрөмдсөн нарийн бөгөөд гүнзгий нүх; *нефтийн цооног.*

ЦООНОГЛОХ 1. цооног нүх ухах; 2. амьтны ичсэн нүхний ичээний дээгүүр ухаж нүх гаргах.

ЦООНОГЛУУЛАХ цооногдохын үйлдүүлэх хэв.

ЦООНОГРОХ цооног болох.

ЦООНОГТОХ цооногтой болох, цооног гарах.

ЦООР I цуур I.

ЦООР цуур II.

ЦООРДОХ цоор хөгжмөөр тоглох; *сайхан цоорддог хүн байна.*

ЦООРДУУЛАХ цоордохын үйлдүүлэх хэв.

ЦООРОХ юманд нүх гарах, цоорхой болох; *хувингийн ёроол цоорох.*

ЦООРУУЛАХ цоорохын үйлдүүлэх хэв.

ЦООРХОЙ 1. юмны цоорч онгорхой болсон газар: **онгорхой цоорхой** хор ш.; *гэрийн цоорхой;* **хагархай цоорхойгоо хатгах** (урагдсан цоорсныг оёх); 2. юмны чөлөө газар; *ойн цоорхой; үүлний цоорхой.*

ЦООХОР I 1. хүний нүүрийн нөрөөтэй сэвхтэйгий нь; *цоохор царайтай хүн;* 2. морь малын чухам зүсмээс гадна өнгийн дусал бийгий нь; *алаг цоохор; эрээн цоохор; бидэртэй цоохор;* 3. алаг эрээн хольцонгуй өнгөтэйгий нь; *цоохор даавуу; цас ов тов цоохор болж байна;* **цоохор тоть** (алаг тоть); **цоохор цүрхээ** амьтан (зэвэгтэй адилхан, бөрттэй хайрстай нэгэн зүйл загас); **цоохор болжмор** амьтан (хядруу бялзуухайгаас томоохон, толгой хар, хүзүү алаг, ар жигүүр харавтархан шар цагаан өнгө холилдсон өнгөтэй нэг зүйл шувуу); **цоохор хулс** ургамал (хулс модны нам, цоохор дурстай нэг зүйл хулс); **цоохор майз** ургамал (шүхэр цэцгийн язгуурт багтах идэшний таримал ногоо, навч ба үндсийг идшинд хэрэглэнэ).

ЦООХОР II ургамал навч жижиг бөгөөд хушуутай, зэрлэг ургадаг нэгэн зүйл ногоо.

ЦООХОР III бог малд тохиолдох нэгэн зүйл өвчин.

ЦООХОР IV бичиг зохиолын навтраг ноорог; *бичгийн цоохор.*

ЦООХОРДОХ хэтэрхий цоохор болох.

ЦООХОРДУУЛАХ цоохордохын үйлдүүлэх хэв.

ЦООХОРЛОХ 1. юмыг цоохор болгох; 2. бичгийн эх цоохор зохиох.

ЦООХОРЛУУЛАХ цоохорлохын үйлдүүлэх хэв.

ЦООХОРТОХ I цоохор болох; *цас цоохортох; газар цоохортож байна; нүүр цоохортох.*

ЦООХОРТОХ II бог малд цоохор өвчин тохиолдох.

ЦООХОРТУУЛАХ цоохортохын үйлдүүлэх хэв, цоохор болгох.

ЦООЧИХ байн байн цоолох; 2. юмны энд тэндээс цоолж авах.

ЦООЧУУЛАХ цоочихын үйлдүүлэх хэв.

ЦОР I: **цор ганц, цорын ганц** гав ганц, ор ганц; *хичээл давтдаггүй хүн цорын ганц байна.*

ЦОР II: **цор цор хийх** 1. бага хүүхдүүдийн хэрэлдэх; 2. багачуудын бага зэрэг ханиалгах; 3. олны тэмцэн цуугилцах; 4. бялзуухай зэргийн цурхиралдах дуу гарах.

ЦОРВОЙЛГОХ цорвойхын үйлдүүлэх хэв; *хушуу цорвойлгох.*

ЦОРВОЙХ хүн амьтны уруул ам цоровгор болох; *ам цорвойх; хушуу цорвойх.*

ЦОРВОЛЗОХ хүн амьтны хушуу байн байн цорвойх.

ЦОРВОЛЗУУЛАХ цорволзохын үйлдүүлэх хэв.

ЦОРГИЛОХ 1. байн байн цоргих; 2. гал утаа оргилох.

ЦОРГИУЛ улайтгаж юмыг цоргин цоолж нүхлэх төмөрлөг хэрэгсэл; *цоргиул төмөр.*

ЦОРГИУЛАХ цоргихын үйлдүүлэх хэв.

ЦОРГИХ 1. улайтгасан төмрөөр юмыг түлж нүхлэх; 2. шилжсэн юмны халуун илч уур юманд хүрч халааж цоноох; *цайны уур гар өвдцоргих; нарны илч туск цоргих.*

ЦОРГО сав суулга зэрэг юмны цутган гарахад зориулсан сүв бүхий газар; *бүрхээрийн цорго; данхны цорго; усны цорго.*

ЦОРГОЛОХ цоргоор дамжуулан асгах.

ЦОРД амьтан мөрөн голд орших нэгэн зүйл загас, нүд улаан, ам том.

ЦОРДОН нэг зүйл жижиг нарийн бүрээ.

ЦОРЖ шашны сүм, дацангийн хурал номын үйлийг толгойлох хүний тушаал.

ЦОРОВ морь малын дээд уруулын хэсэг газар.

ЦОРОВГОНОХ цоровгор юмны үргэлжлэн хөдлөх; *уруул нь цоровгонох.*

ЦОРОВГОНУУЛАХ цоровгонохын үйлдүүлэх хэв.

ЦОРОВГОР амьтны хушуу уруул унжгар, цөрөвгөрий нь; *цоровгор уруултай хүүхэд.*

ЦОРОВДОХ морь малын ам уруулаас нь уях, барих, амдах ч гэдэг; *морь цоровдох.*

ЦОРОЙ 1. хэвлийн дотоодод хөндлөн ташаалж тогтсон мах; 2. ярианд өвчүүний хормой; *өвчүүний цорой; цоройтой өвчүү;* **цорой татах** (цоройн тус газар татаж өвдөх нэгэн зүйл өвчин).

ЦОРОЙЛГОХ цоройход хүрүүлэх.

ЦОРОЙЛОХ байн байн цоройх; *хураасан аргал дээр ишиг цоройлж байв.*

ЦОРОЙХ 1. өндөр юм өөд буюу дээш асах, дэгдэн авирах; *мод өөд цоройх; гэр өөд цоройх; уул өөд цоройх;* 2. морь мал хойт хоёр хөл дээрээ босох; *морь цоройх.*

ЦОРОЛ ургамал нийлмэл цэцгийн язгуурын, жижгэвтэр ягаан баг цэцэгтэй, олон наст ургамал, төрөл зүйл олон, заримыг эмнэлэгт хэрэглэнэ.

ЦОРС дөрвөн ойрдын нэгэн овог.

ЦОРХИРУУ амьтан ой хөвчид амьдарна, тахианы багт хамаарагддаг бөгөөд өвөлждөг нэгэн зүйл шувуу, агнуурт хэрэглэнэ, зарим нутагт торхируу гэдэг.

ЦОХ I хүний магнайн хоёр хажуугийн ба магнайн дээдхэн хэсгийн газар; **цох авах** (хүний цохон дээр няслах, цохдох ч гэнэ).

ЦОХ II юмны хольцонгуйгүй дан нэг өнгөтэйгий нь; *цох хүрэн; цох хар; цох цагаан.*

ЦОХ III: **цох хорхой** амьтан хатуу хальстай, жигүүр бүхий шавьж, биеийн урт нь 0,25 мм—15 см байдаг, төрөл зүйл маш олон, бас хэлбэр байдал ч янз бүр, цох хорхойнуудын зарим нь ашигтай боловч зарим нь хортой.

ЦОХДОС 1. хуучирсан бичгийн завсарт хавчуулж цохолт хийхэд бэлтгэсэн зурвас цаас; 2. цохолт хуудас ба бичиг.

ЦОХДОХ 1. цох дээр няслах, цох авах ч гэдэг; 2. даалуу хөзөр зэргээр наадахад гарын зөвөөр өрсөн хожих.

ЦОХДОГДОХ цохдохын үйлдэгдэх хэв.

ЦОХДУУЛАХ 1. цохдохын үйлдүүлэх хэв; 2. цохдогдох.

ЦОХИГДОХ 1. цохихын үйлдэгдэх хэв; 2. дийлдэх, давагдах, ялагдах.

ЦОХИЛОХ юмыг байн байн цохих ба олныг цохих дэлдэх.

ЦОХИЛТ цохих үйлийн нэр; *цохилт өгөхөд бэлхэн байх хэрэгтэй; цагийн цохилт сайн байна.*

ЦОХИЛУУЛАХ цохилохын үйлдүүлэх хэв.

ЦОХИМОГ шанз махыг бөөрөнхийлөн хайрч болгосон нэг зүйл хоол; *цохимог идэх.*

ЦОХИО I онцгойлон тогтсон өндөр хад; *хадан цохио; улаан цохио.*

ЦОХИО II машины моторын гэмтэл; *машин цохиотой байна; мотор цохиж байна; цохио нь ихдэж байна.*

ЦОХИУЛАХ 1. цохихын үйлдүүлэх хэв; 2. цохигдох.

ЦОХИХ 1. жанчих, дэлдэх; *хүн амьтныг зодож цохих; сүхээр цохих; хэмх цохих; тас цохих; зад цохих; хага цохих; ташуураар цохих;* 2. дийлэх, давах, ялах; *буруу үзэл санааг шүүмжлэлээр зад цохих; дайсныг бүсэлж бут цохих;* 3. жигд цохилттой юмны хөдлөх; *миний цаг сайн цохиж байна; зүрх цохих;* 4. хөгжмийн зэвсгийг дэлдэж дуугаргах; *хөгжим цохих; хонх цохих; бөмбөр цохих ёочин цохих; шудрага хөгжим цохих;* 5. салхи зэрэг юм гэнт дэлсэх; *салхи цохих; жавар цохих; зүргийн цаасыг гэрэл цохьсон байв; тариаг мөндөр цохих;* ☆ **утас цохих** (цахилгаан мэдээ явуулах); *улаан буурал морь нь, усаа уухыг больжээ, уур нь хүрсэн юм үү хөө, утас цохихыг байлаа хөө* (ардын дуу): **машина цохих** (бичгийн машинаар юм бичих); **туйпуу цохих** (туйпууг хэвт хийж үйлдэх).

ЦОХЛОХ I олныг буюу байн байн цохох.

ЦОХЛОХ II олны дотроос онцлон зааж гаргах.

ЦОХОЛТ цохдос; *цохолттой бичиг; даргын цохолт; цохолтоор юм авах.*

ЦОХОХ I 1. аливаа бичиг хэрэгт, удирдах хүмүүсээс хэрхэн гүйцэтгэвэл зохих тухай заасан товч шийдвэр бичих; *бичиг цохох;* 2. зарим хянасан, үзсэн, байцаасан бичиг хэргийнхээ дээр нь тэмдэг гавих; *данс дээр цохох.*

ЦОХОХ II олон юмны дотроос онцлон зааж гаргах; *нэр цохох.*

ЦОХРОЖ амьтны нэгэн дор цугларсан газар.

ЦОХРОЛДОХ амьтны нэгэн газарт цугларч ихэд шаваарадлан овоорох.

ЦОХРОХ амьтны юм хумд цугларч овооролдох.

ЦОХРУУЛАХ цохрохын үйлдүүлэх хэв.

ЦОХУУЛАХ цохохын үйлдүүлэх хэв.

ЦОЦОХ юмны байдал төлөв сая тохирох.

ЦОЦУУЛАХ цоцохын үйлдүүлэх хэв.

ЦОЦУУРЬ харгис муу хүн.

ЦОЧИМТГОЙ сочимхой.

ЦОЧИМХОЙ 1. маш хялбархан цочдог; 2. аймтгай, сочимтгой.

ЦОЧИР гэнт, сочмог; *цочир хүйтэн болов; цочир өвдөв; цочир шийдвэрлэв.*

ЦОЧИРДОХ хэтэрхий цочир болох.

ЦОЧИРДУУЛАХ цочирдохын үйлдүүлэх хэв.

ЦОЧИХ ямар нэгэн юмнаас гэнт хэлмэж догдолсхийх; **айх цочих** х о р ш.; *хүүхэд битгий цочоогоорой;* **булчирхай цочих** (булчирхай овойж хавдах).

ЦОЧМОГ гэнт, түргэн; *цочмог ууртай хүн; цочмог зантай морь; цочмог өвчин хүрэх.*

ЦОЧМОГДОХ хэтэрхий цочмог болох.

ЦОЧМОГДУУ цочмог зан байдалтай; *сүрхий цочмогдуу зантай хүн байна билээ; цочмогдуу өвчин хүрэх.*

ЦОЧМОГДУУЛАХ цочмогдохын үйлдүүлэх хэв.

ЦОЧОО тоомсор, дуулгар, хөдөлгөө; *цочоо орох; цочоо суух; юу ч болж байсан цочоогүй болсон амьтан.*

ЦОЧООЛГОХ цочооход хүргүүлэх.

ЦОЧООХ цочихын үйлдүүлэх хэв.

ЦӨВ I өрөм тосны тосы нь ялгаж аваад үлдсэн шараг хувь; *өрөмний цөв; тосны цөв.*

ЦӨВ II саад, тотгор; **цөв орох** (сайн юманд садаа орох); **цөвийн цаг** (доройтож буурсан цаг улирал).

ЦӨВДӨЛ идэх юмны жижигхэн өөдөс өвдөл; **өвдөл цөвдөл, өөдөс цөвдөл** х о р ш.; *махны цөвдөл; талхны цөвдөл.*

ЦӨВДӨЛДӨХ хэтэрхий цөвдөл болох.

ЦӨВДӨЛЛӨХ цөвдлий нь ялгах.

ЦӨВДӨЛРӨХ цөвдөл болох.

ЦӨВДӨЛТӨХ цөвдөлтэй болох.

ЦӨВРҮҮ цэврүү.

ЦӨВРҮҮТЭХ цэврүүтэх.

ЦӨВТӨХ I юманд цөв тогтох, цөвтэй болох; *тос цөвтөх.*

ЦӨВТӨХ II 1. цөв орох, цөвгэй болох; 2. дордож буурах.

ЦӨВТҮҮЛЭХ цөвтөхийн үйлдүүлэх хэв.

ЦӨГДИЙХ бөгцийх, түгдийх.

ЦӨГЦ I 1. зул барих, тахил тавих зэрэгт хэрэглэх нэг зүйл жижиг аяга; *тахилын цөгц; усны цөгц; зулын цөгц*; 2. аяганы хүндэтгэл; *хүүхдийн цөгц.*

ЦӨГЦ II адууны үүдэн шүдний голын хонхор газар; *цөгц сайтай морь; цөгц нь барагдаж яваа морь.*

ЦӨГЦГӨР цөмцгөр, бэмбэгнүүр байдалтай.

ЦӨГЦИЙЛГӨХ цөгцийхөд хүрүүлэх.

ЦӨГЦИЙХ хүн амьтны биеэ хураах цөмцийн байх; *цөгцийж суух; цөгцийж зогсох.*

ЦӨГЦЛӨХ I юмыг цөгцөнд хийх.

ЦӨГЦЛӨХ II адууны шүдэнд цөгц бий болон тогтох.

ЦӨГЦӨГНӨХ 1. хүнийг бялдуучлан их л шилтгэнэх; 2. цөгцгөр юмны цөгцөг цөгцөг хөдлөх.

ЦӨГЦӨГНҮҮЛЭХ цөгцөгнөхийн үйлдүүлэх хэв.

ЦӨГЦӨЛЗӨХ 1. бялдуучлан шилтэгнэх; 2. цөгцгөр юмны цөгцөс цөгцөс хөдлөх.

ЦӨГЦӨЛЗҮҮЛЭХ цөгцөлзөхийн үйлдүүлэх хэв.

ЦӨГЦҮҮРЭГ: цөгцүүрэг авах зоо авах.

ЦӨЛ хүнгүй буюу хүн амьтан огт байхгүй зэлүүд газар: **зэлүүд цөл, говь цөл** х о р ш.; *цөл газар; цөл тал; хээр цөл; цөл нутаг; цөл говь;* **элсэн цөл** (элсэн манх бүхий зэлүүд газар).

ЦӨЛБӨХ 1. юмыг нэг нэгхнээр түүх; *цөлбөн түүх;* 2. цөлмөх; *цөлбөн хураах; цөлбөн авах.*

ЦӨЛБҮҮЛЭХ 1. цөлбөхийн үйлдүүлэх хэв; 2. цөлбөгдөх.

ЦӨЛИЙЛГӨХ цөлийхөд хүрүүлэх.

ЦӨЛИЙХ муудах, буурах.

ЦӨЛЛӨГ өөр газар явуулах ял; цөллөгт явуулах.

ЦӨЛМӨХ бусдын юмыг харман хураж авах; *хөрөнгийг цөлмөх; хоол хүнсийг цөлмөх; цөлмөн хураах; цөлмөн дээрэмдэх.*

ЦӨЛМӨЧИХ нэгмөсөн цөлмөх, дуустал цөлмөх.

ЦӨЛМҮҮЛЭХ 1. цөлмөхийн үйлдүүлэх хэв; 2. цөлмөгдөх.

ЦӨЛӨГДӨХ цөлөхийн үйлдэгдэх хэв.

ЦӨЛӨХ 1. яллаж өөр газар явуулах; 2. юмыг үгүй болгох.

ЦӨЛҮҮЛЭХ цөлөхийн үйлдүүлэх хэв.

ЦӨМ I бүгд; *цөм миний юм; бид цөм нэг саналтай байна; цөм бэлэн болсон; ажилд цөм гарцгаах хэрэгтэй; цөмийн буруу; цөмтэй нь уулзана; цөмийг авчир; цөмөөс асууж мэд; цөмөөрөө ирсэн байна.*

ЦӨМ II өм; **өм цөм** х о р ш.; *цөм татах; цөм цохих; цөм хатгах.*

ЦӨМ III бодисын үндсэн цулаас бүтсэн, атомын гол хэсэг; **цөмийн зэвсэг** (цөмийн энергийг ашиглаж хийсэн зэвсэг); **цөмийн урвал** (атомын цөмийн нийлэх, хувирах, задрах урвал); **цөмийн дайн** (цөмийн зэвсэг хэрэглэж дайтах дайн); **цөмийн физик** (цөмийн бүтэц, цөмийн урвал, цөмд явагдах бүх үзэгдлийг судлах физикийн ухааны салбар).

ЦӨМ IV цөмөө.

ЦӨМЛӨЛЦӨХ цөмлөхийн үйлдэлцэх хэв.

ЦӨМЛӨХ цөмрөхөд хүрүүлэх.

ЦӨМЛҮҮЛЭХ 1. цөмлөхийн үйлдүүлэх хэв; 2. цөмлөгдөх.

ЦӨМӨӨ жимс зэргийн дотоодод байх үр идээ; *самрын цөмөө, хушганы цөмөө.*

ЦӨМӨӨТӨХ 1. тарианы үрлэх; *тариа цөмөөтөх*; 2. цөмөө тогтох; *самар цөмөөтөх.*

ЦӨМӨХ цөмөө бүхий юмыг хагалж үрийг идэх; *самар цөмөх; хуасан цөмөх.*

ЦӨМРӨХ цөм орох, өмрөх; **өмрөх цөмрөх** х о р ш.; *мөс цөмрөх; нух цөмрөх.*

ЦӨМРҮҮЛЭХ цөмрөхийн үйлдүүлэх хэв.

ЦӨМҮҮЛЭХ цөмөхийн үйлдүүлэх хэв.

ЦӨМЦГӨР цомцгор, цэмцгэр, цөмцийсөн юм.

ЦӨМЦГӨРДӨХ хэтэрхий цөмцгөр болох.

ЦӨМЦГӨРДҮҮЛЭХ цөмцгөрдөхийн үйлдүүлэх хэв.

ЦӨМЦИЙЛГӨХ цөмцийхийн үйлдүүлэх хэв.

ЦӨМЦИЙХ цөмцгөр болох; *цөмцийж суух.*

ЦӨМЦРӨХ цомцрох; *цөмцөрч явах гишгэх.*

ЦӨМЦРҮҮЛЭХ цөмцрөхийн үйлдүүлэх хэв.

ЦӨМЧИХ I байн байн цөмрөх.
ЦӨМЧИХ II хүн амьтны ядарч мацах.

ЦӨМЧҮҮЛЭХ цөмчихийн үйлдүүлэх хэв.

ЦӨН I тэрэгний голд хамгаалалт бэхэлгээ болгож хийх төмөрлөг; *тэрэгний цөн; цөн суулгах.*

ЦӨН II хаврын цагт мөс гэсч хэврэгшсэнээс болон хагарч салсан хэсгий нь; *цөн гүйх; мөсний цөн; цөн түрэх.*

ЦӨНХРӨГ I модны шавдал, жимсний иш зэргийн хатаж ургасан уулзвар газар.

ЦӨНХРӨГ II тэмээний нөөц тэжээл агуулах сав.

ЦӨӨВӨР I цөөвтөр; *уулын ард цөөвөр адуу байна.*

ЦӨӨВӨР II: **цөөвөр чоно** а м ь т а н нохойн нам, өнгө шар, нохойтой адил болоод чононоос бяцхан, үнэгнээс том, шувуу, ан гөрөөс, мал хөнөөхөөс гадна хүнд ч халдах нь бий, шарнууд ч гэдэг.

ЦӨӨВЧЛӨХ цөөн болгох, цөөхөн болгох.

ЦӨӨВЧЛҮҮЛЭХ цөөвчлөхийн үйлдүүлэх хэв.

ЦӨӨДӨХ хэтэрхий цөөн болох; *энэ номноос олон хувь авчрахгүй яасан юм бэ, цөөдөөд байна.*

ЦӨӨДҮҮЛЭХ цөөдөхийн үйлдүүлэх хэв.

ЦӨӨЛӨХ цөөн болгох, цөөхөн болгох; *орон тоог цөөлөх.*

ЦӨӨЛҮҮЛЭХ цөөлөхийн үйлдүүлэх хэв.

ЦӨӨН олон биш; *хүн бүл цөөн; цөөн болох; үгний цөөн нь дээр, үхрийн олон нь дээр* х у у ч; ☆ **бөөн цөөн** (бүхэл ихээр нь; *бөөн цөөнөөр нь өгөх*).

ЦӨӨНХ цөөхөнх; *цөөнхийн санал;* **цөөнх үндэстэн** (цөөн хүн амтай үндэстэн).

ЦӨӨРГӨНӨ а м ь т а н царцаахайн нам, бэлхүүс урт нэгэн зүйл хорхой.

ЦӨӨРӨМ 1. бяцхан нуур; *цөөрөм байгуулах;* 2. урсгал усны өвлийн цагт хөлддөггүй задгай харз гүн устай өрх газар; **өмхий цөөрөм** (өвөл хөлддөггүй цөөрөм).

ЦӨӨРӨХ цөөн болох, цөөхөн болох; *гэмт хэрэг үйлдэх явдал жилээс жилд цөөрч байна;* **хөл цөөрөх** (олон хүний ирж очих нь цөөн болох; *зочдын хөл цөөрсөн дээр явж кино үзээд ир*).

ЦӨӨРС у р г а м а л гачууртай адил болоод шилмүүс хавтгай нэг зүйл мод, газар газар зөөлөн хатуу адилгүй, цөргөс ч гэдэг.

ЦӨӨРҮҮЛЭХ цөөрөхийн үйлдүүлэх хэв.

ЦӨӨСГӨХ цөөтгөх.

ЦӨӨСӨХ цөөтөх.

ЦӨӨТГӨХ цөөтөхөд хүргүүлэх.

ЦӨӨТӨХ улам цөөн болох.

ЦӨӨХӨН баахан цөөн, олон биш; *цөөхөн мал билчиж явна; цөөхөн нь олондоо автагдана.*

ЦӨӨХӨНХ цөөнх; *олонхийн саналаар болж, цөөнхийн саналыг хүчингүй болгов.*

ЦӨӨХРӨХ цөөхөн болох, цөөрөх.

ЦӨР янз бүрийн хос давсны нэр.

ЦӨРВИЙЛГӨХ зөрвийхөд хүргүүлэх.

ЦӨРВИЙХ цөрөвгөр болох; *хушуу цөрвийх.*

ЦӨРВӨЛЗӨХ цөрөвгөр юмны байн байн цөрвийх.

ЦӨРГӨР чөргөр.

ЦӨРИЙЛГӨХ цөрийхийн үйлдүүлэх хэв.

ЦӨРИЙХ цөргөр болох, цоройх ч гэдэг.

ЦӨРӨВГӨНӨХ цөрөвгөр юмны үргэлжлэн хөдлөх.

ЦӨРӨВГӨР цоровгор, хушуу ам урт унжуу, цоровгор ч гэдэг; *цөрөвгөр хушуутай.*

ЦӨРӨМ бог малын сүүг тусгай саванд хурааж гашилгасны нь; *цөрөм хураах; цөрөмний ааруул.*

ЦӨРЧГӨР чөргөр нарийн хөлтэй туранхай, хорчгор.

ЦӨРЧГӨРДӨХ хэтэрхий цөрчгөр болох.

ЦӨРЧГӨРДҮҮЛЭХ цөрчгөрдөхийн үйлдүүлэх хэв.

ЦӨРЧИЙЛГӨХ цөрчийхийн үйлдүүлэх хэв.

ЦӨРЧИЙХ цөрчгөр болох.

ЦӨС I элэгнээс боловсруулан гаргах шар ногоон өнгөтэй, гашуун амттай шингэн зүйл.

ЦӨС II: **цөс өвс** ургамал ойт хээрийн бүсэд чийг нуга газар, ойн хаяагаар ургадаг, холтсон цэцгийн язгуурын олон наст ургамал, зарим газар буржгар ч гэдэг, малын тэжээлд хэрэглэхээс гадна эмнэлэгт хэрэглэнэ.

ЦӨСТӨХ цөсний өвчин хүрэх.

ЦӨХЛИЙТӨХ шагааг хуруугаар хавчиж алцуу босгон орхих.

ЦӨХ гурван настай буга.

ЦӨХӨГ идэх юмны зажлахад агшуун нэмүүнгүйгий нь.

ЦӨХӨГШИХ 1. урмас хугарч санаа цөхрөх; 2. мод зэргийн юмны хүндэд дарагдаж гажих.

ЦӨХӨӨХ цөхөхөд хүрүүлэх.

ЦӨХӨРГӨХ цөхрөхөд хүрүүлэх, цөхрүүлэх.

ЦӨХӨХ ядах, зүдэх, цөхрөх; *би гуйж цөхөөд байсан нь... цөхөж ядах.*

ЦӨХРӨЛТ цөхөрсөн нь, ядралт, зүдрэлт.

ЦӨХРӨЛТГҮЙ цөхрөхгүй, уйгагүй, цуцалтгүй; *цөхрөлтгүй зүтгэх.*

ЦӨХРӨӨХ цөхөргөх.

ЦӨХРӨХ үйл ажлыг чадахгүйд хүрч ядран үхшрэх, бэрхшээх болох, цөхөх.

ЦӨХРӨШГҮЙ цөхрөх шинжгүй, цөхрөлтгүй.

ЦӨХРҮҮЛЭХ цөхрөхийн үйлдүүлэх хэв.

ЦӨХҮҮЛЭХ цөхөхийн үйлдүүлэх хэв.

ЦӨЦГИЙ сүүний дээгүүр өрөмтөж тогтсон тослогийн хувь; **цөцгийн тос** (цөцгийг боловсруулан хийсэн тос).

ЦӨЦГИЙРӨХ цөцгий болох, цөцгий суух.

ЦӨЦГИЙШИХ цэцгийн шинжтэй болох.

ЦӨЧГӨР туранхай, нарийн; *цөчгөр хурга; цөчгөр уурга.*

ЦӨЧИГНӨХ цөчгөр юмны үргэлжлэн хөдлөх.

ЦӨЧИЙЛГЭХ цөчихийн үйлдүүлэх хэв.

ЦӨЧИЙХ цөчгөр болох.

ЦӨЧИЛЗӨХ цөчгөр юмны байн байн хөдлөх.

ЦУВ бороо цаснаас хувцас хамгаалж өмсөх гадуур хувцас.

ЦУВАА (Н) 1. цувж яваа юм; *малын цуваа; жингийн цуваа; машины цуваа; галт тэрэгний цуваа; цэргийн цуваа;* 2. юмны дэс дараагаар оноож бичсэн данс цэс; *бөхийн цуваа; хурдан морины цуваа; сур шагааны цуваа; цуваа бичих;* 3. мал адгуус явсан жим зам; *цуваа зам.*

ЦУВАЛДАХ цувахын үйлдэлдэх хэв, үргэлжлэн цувах.

ЦУВАН: уван цуван юмны дараа дараагаар болох; *уван цуван ирэх; уван цуван явах; уван цуван идэх.*

ЦУВАХ 1. ус зэргийн шингэн ба зөөлөн нойтон ширхэгтэй юмны нарийн тэгшээр урсах, гоожих; *ус цувах; үр будаа цувах; шороо шавар цувах;* 2. аливаа амьтан ба хөдөлгөөтэй юмны дагалдаа дагалдаагаар орших, зорчих; *хүн амьтан цувах; өрөх цувах; цувж орох хэрэгтэй; цувж явсан барсаас, цуглаж суусан шаазгай дээр* сэцэн; 3. эвхэгдсэн атирсан, нэхсэн, ээдэрсэн юмыг хөвөх, тэнийлгэх, сэмлэх; *дээс цувах; утас цувах; унгас цувах; хонины холбоо цувах;* 4. цувалдах, цуврах, суврах.

ЦУВДАЙ бог малын гэдэс дотрын зүйл.

ЦУВРАХ 1. хүн амьтан ба юмны дараа дараагаар цувалдан явах, орших, цувах, суврах ч гэдэг; *цуварч ирэх;* 2. юмны бага багаар гоожих, асгарах; *цус цуврах; тариа будаа цуврах; шүлс цуврах.*

ЦУВРУУЛ хотын доторхи газар доогуур буртагт зүйлийг урсгах нүх; *бохир усны цувруул.*

ЦУВРУУЛАХ цуврахын үйлдүүлэх хэв.

ЦУВУУЛАХ цувахын үйлдүүлэх хэв.

ЦУВХ: цувх зулгарах модны навч хийсч унах.

ЦУВЦ цувж явдаг нарийн жим.

ЦУГ хамт; *цуг явах; цуг хийх; цуг суух; олон нөхөдтэйгөө цуг байх сайхан;* **цуггаа** (нэгэн хамт; *цуггаа ажилладаг хоёр; надтай цуггаа яваад ирсэн хүн).*

ЦУГААР бүгдээр, хамтаар; *цугаараа ирсэн байв.*

ЦУГЛААН улс төрийн болон аливаа хойшлуулшгүй чухал асуудлыг хэлэлцэх олны түр хурал; *үйлдвэрийн ажилчдын цуглаан болов.*

ЦУГЛАВАР цугласан юм.

ЦУГЛАЛАХ олнооров хамт зорчин явах.

ЦУГЛАРАЛ 1. цугларах үйлийн нэр; 2. үлэмж хурсны нь.

ЦУГЛАРАЛТ цугларах үйлийн нэр; *хичээлийн цугларалт.*

ЦУГЛАРАХ давхцан хуралдах, хурж бөөгнөрөх.

ЦУГЛАРУУЛАХ цугларахын үйлдүүлэх хэв.

ЦУГЛАХ 1. хүн амьтан, эд юмны нэгэн газарт олноор хурах, цугларах; **хурах цуглах** хорш.; 2. боох, баглах, цуг болгох, юмыг нэгтгэн цомхотгож боох, баглах; **боох цуглах** хорш..

ЦУГЛУУЛАГЧ цуглуулах үйл гүйцэтгэгч этгээд.

ЦУГЛУУЛАХ цуглахын үйлдүүлэх хэв; *аргал цуглуулах; түүхий эд цуглуулах; марк цуглуулах; ном судар цуглуулах.*

ЦУГЛУУЛБАР цуглуулсан юм; *цуглуулбар зураг.*

ЦУГЛУУЛГА 1. цуглуулсан юм; *ургамлын цуглуулга; данс харааны цуглуулга; ховор ном бичгийн цуглуулга;* 2. музейн үзмэрт зориулж цуглуулсан юмс; *хүрэл зэвсгийн цуглуулга.*

ЦУГНАХ цунгаар хэмжих.

ЦУЛ I 1. юмны хөндийгүй; *цул төмөр; цул чулуу;* **таван цул** (зүрх, элэг, уушиг, дэлүү, бөөр энэ тав); **зургаан цул** (сөс, ходоод, олгой, нарийн гэдэс, давсаг, гурван самшиу энэ зургаа); 2. цэвэр, хольцгүй, дангаар; *цул алт; цул мөнгө; цул хуш;* **цул мах** (ясгүй мах); 3. нэг өнгийн; *цул улаан; цул хар;* **цул сараана** ургамал (тахианы өндөгний хиртэй том нэгэн зүйл сараана, хальсны өнгө хөхөвтөрхөн, боловсруулж иднэ).

ЦУЛ II: **цул цул хийх** шингэн юм зайлагдан дуугарах чимээ.

ЦУЛБУУР хазаар ногтод, морь малыг хөтлөх уяхад зориулагдсан байдаг сур дээс зэрэг оосор: **жолоо цулбуур** хорш.; **цулбуур өвс** ургамал говь хээрийн бүсэд ургадаг нэг зүйл өвс, өндөр нь 30—40 сантиметр, цэцгийн өнгө цайвар хөх, хавар цэцгий нь ямаа дуртай иднэ).

ЦУЛБУУРДАХ морины хазаарын цулбуураас барьж авах.

ЦУЛБУУРДУУЛАХ цулбуурдахын үйлдүүлэх хэв.

ЦУЛБУУРТ амьтан лах загастай адил бөгөөд арай бага нэгэн зүйл загас, том нь хоёр тохойгоос хэтрэхгүй.

ЦУЛГУЙ 1. хээ янз, маяг гаргаж чимэглээгүй шулуун хийцтэй юм; *цулгуй даавуу; цулгуй авдар; цулгуй хувин;* 2. өөр өнгө хольцолдоогүй дан нэг өнгөтэй юм; *цулгуй улаан цэмбэ; цулгуй будагтай хайрцаг; цулгуй хүрэн гутал.*

ЦУЛГУЙДАХ 1. хэтэрхий цулгуй болох; 2. найр хурим зэрэгт хэрэглэхүүний зүйл ховор дутмаг буюу байхгүй байх.

ЦУЛГУЙДУУЛАХ цулгуйдахын үйлдүүлэх хэв.

ЦУЛГУЙЛАХ арьс үст зүйлийг идээ оруулах, бүдүүвчлэн элдэх; *нэхий цулгуйлах; шир цулгуйлах.*

ЦУЛГУЙЛУУЛАХ цулгуйлахын үйлдүүлэх хэв.

ЦУЛГУЙРАХ цулгуй болох.

ЦУЛГУЙРУУЛАХ цулгуйрахын үйлдүүлэх хэв.

ЦУЛГУЙШИХ цулгуйн шинжтэй болох.

ЦУЛХАЙРАХ цулгуйрах.

ЦУЛХАЙХ цулхгар болох.

ЦУЛХАЛЗАХ цулхгар юмны цулхас цулхас хөдлөх.

ЦУЛХАН модны том ур цулцан.

ЦУЛХГАНАХ цулхгар юмны цулхга цулхга хөдлөх.

ЦУЛХГАР цунцгар, цулхгэр; *цулхгар гэдэс; цулхгар хацар.*

ЦУЛХИР у р г а м а л их элстэй газар ургадаг ургамал, гол иш бүдүүн, салаа гишүүнь хөндлөн тийш ургадаг бөгөөд үндэс талынхнь урт, дээш улам богино ургасан нь сувраганы хэлбэртэй, навч хавтгай бөгөөд шөвгөр, түрүүд нь бөөн бөөн буурцаг гарна, навч буурцаг цөм өргөстэй, өнгө улаавтар, тэмээ дуртай иднэ, үрийг боловсруулж идвэл хүнд зохимжтой; **цулхирын гурил** (цулхирын үрийг боловсруулж хийсэн гурил).

ЦУЛЦАЙЛГАХ цулцайхын үйлдүүлэх хэв.

ЦУЛЦАЙХ юмны цулцгар болох.

ЦУЛЦАЛЗАХ цулцгар юмны цулцас цулцас хөдлөх.

ЦУЛЦАЛЗУУЛАХ цулцалзахын үйлдүүлэх хэв.

ЦУЛЦАН хүн малын биед товойн гарч тогтсон бондгор ур мэт юм, хятуу ч гэдэг, бас ашиг цулцан ч гэнэ.

ЦУЛЦАНТАХ цулцан гарч тогтох.

ЦУЛЦГАНАХ цулцгар юмны цулцга цулцга хөдлөх.

ЦУЛЦГАНУУЛАХ цулцганахын үйлдүүлэх хэв.

ЦУЛЦГАР цунцгар байдалтай юм; *цулцгар хацартай; цулцгар өвх; цулцгар махтай.*

ЦУЛЦГАРДАХ хэтэрхий цулцгар болох.

ЦУЛЦГАРДУУЛАХ цулцгардахын үйлдүүлэх хэв.

ЦУЛЧИГ хүний хэл муу, үг тодорхойгүйгий нь; *хэл нь цулчиг хүүхэд.*

ЦУЛЧРАХ хүний үгээ тодорхой хэлж чадахгүй болох; *хэл цулчрах.*

ЦУМ цом, авсаар, аятай.

ЦУМХАН цомхон, авсаархан.

ЦУМХАТГАХ цумхтахын үйлдүүлэх хэв.

ЦУМХРАХ цумхан болох, цомхон болох, цомхрох.

ЦУМХРУУЛАХ цумхрахын үйлдүүлэх хэв.

ЦУМХТАХ улмаар цумхан болох.

ЦУН урт богинын хэмжүүр, ямх; *хэдэн цунгийн банз вэ?*

ЦУННАХ цунгаар хэмжих, цугнах.

ЦУНХИАЛ усны аюултай маш гүн газар, цүнхээл ч гэдэг.

ЦУНЦАЙЛГАХ цунцайхын үйлдүүлэх хэв.

ЦУНЦАЙХ цунцгар болох.

ЦУНЦАЛЗАХ цунцгар юмны байн байн цунцас цунцас хөдлөх.

ЦУНЦГАНАХ цунцгар юмны үргэлжлэн цунцга цунцга хөдлөх.

ЦУНЦГАР бумбагар, цулцан байдалтай юм; *цунцгар хацартай; цунцгар булчинтай.*

ЦУНЦГАРДАХ хэтэрхий цунцгар болох.

ЦУНЦГАРДУУЛАХ цунцгардахын үйлдүүлэх хэв.

ЦУР I 1. аарцыг өрөмтэй багсарч хийсэн ааруул; 2. бог малын сүүгээр хийсэн ааруул.

ЦУР II: **цур цар хийх** хүн амьтны олноор тэмцэн цуугилцах, цурхилдах.

ЦУРААХ цурахын үйлдүүлэх хэв.

ЦУРАВ I усны шувуунуудын томхон болсон дэгдээхэй; *нугасны цурав; галууны цурав;* **цурав ногоо** (а. хавар сая гарсан өндөрхөн ногоо; б. түймэрт шатсан газраас шинэхэн ургасан ногоо).

ЦУРАВ II түймэрт шатсан газар; *түймрийн цурав.*

ЦУРАВДАЙ гургуулын зулзага, алтан цуравдай ч гэдэг.

ЦУРАВДАХ цурамдах.

ЦУРАМ түймрийн цурав.

ЦУРАМДАХ хэтэрхий цурам болох, цуравдах.

ЦУРАМДУУЛАХ цурамдахын үйлдүүлэх хэв.

ЦУРАХ хүйтэнд мөс дэлбэрэх; *мөс цурах.*

ЦУРВАГ тахианы томхон зулзага, цурван ч гэдэг.

ЦУРВАГА тахианы жижигхэн зулзага.

ЦУРВАН цурвага.

ЦУРГА улаан далбаат гэдэг загасны зулзага.

ЦУРХАЙ амьтан хавтгай бөгөөд уртавтар толгойтой, бие урт нэг зүйл махчин загас, цэнгэг усанд амьдарна.

ЦУРХИЛДАХ шуугилдах.

ЦУРХИРАЛ олны дүрхрэн хэлэлцэх шүүмж лэл, маргаан.

ЦУРХИРАЛДАХ олноороо дүрхрэн шагшин хэлэлцэх.

ЦУРХИРАЛЦАХ цурхирахын үйлдэлцэх хэв, олноороо шагшин хэлэлцэх.

ЦУРХИРАХ 1. олноороо дүрхрэн хэлэлцэх; 2. турхирах; **цурхиран уйлах** (эхэр татаж уйлах).

ЦУРХИРУУЛАХ 1. цурхирахын үйлдүүлэх хэв; 2. цурхирагдах.

ЦУС (АН) бүх биеийн эсийг тэжээл ба эдийн солилцоогоор хангадаг, бие махбодын дотуур гүйх шингэн улаан зүйл; **цус нөж** хорш.; **цус хурах** (цус, нэг газар цугларан нөжрөх, хүрэнтэх); **цус асгарах** (цус ихээр гоожих): **цус харвах** (бие махбодын дотор судас гэмтэж цус алдрах); **цус багатай** (хэвийн хэмжээнээс цус нь бага болсон); **цусан хатгалга** (уушигны хүнд өвчин); **цусан суулга, цусан чацга** (гэдэсний халдварт өвчин); **цусаар ханиах** (ханиахад цус гарах болох); **цусны эргэлт** (бие махбодын доторхи цусны гүйдэл); **цус алдах** (судаснаас цус алдран гадагш гарах); **цусны судал** (цус гүйх гуурс хэлбэртэй эрхтэн): **цусны бүлэг** (цусны нийцэх чанараар ангилах бүлэг, нэгдүгээр бүлэгт орох цус ямар ч цустай хүнд тохирно); **цус хямрах** (булчингийн ажиллагааны бодисын солилцоо өөрчлөгдсөнөөс болж үүсэх өвчин); **цусан улаан** (ув улаан); **цусан зээрд** (адууны зүсэм, маш улаан зээрд); **цус буух** (морь малын хөл доголох нэг зүйл өвчин); **цус гаргах** (агнах, алах; *би ч оготны хоншоороос цус гаргаж үзээгүй хүн);* **цусан төрөл** (эхийн төрөл); **цэвэр цусны** (үүлдэр холилдоогүй; *цэвэр цусны азрага).*

ЦУСАРХАГ маш их цустай.

ЦУСАРХАХ цус ихтэй болох.

ЦУСАРХУУ 1. цусархаг; 2. цус мэт.

ЦУСАРХУУЛАХ цусархахын үйлдүүлэх хэв.

ЦУСГҮЙ хэтэрхий цус багатай.

ЦУСГҮЙДЭХ хэтэрхий цусгүй болох .

ЦУСДАХ юманд цус түрхэх.

ЦУСДУУЛАХ цусдахын үйлдүүлэх хэв.

ЦУСЛАЛЦАХ 1. цуслахын үйлдэлцэх хэв; 2. харилцан цус гартал жанчилдах.

ЦУСЛАХ хүн амьтнаас цус гаргаж авах.

ЦУСЛУУЛАХ 1. цуслахын үйлдүүлэх хэв; 2. цуслагдах.

ЦУСТ 1. цус бүхий; 2. шилжсэн хөнөөлт үйл; *цуст дайн; цуст аргаар.*

ЦУСТАЙ цус бүхий; *цустай цэр; цустай гар; цустай хутга.*

ЦҮТГАГЧ цутгуурч.

ЦУТГАЛ 1. цэцэрлэгт ус түрэх сав; 2. цутгалан.

ЦУТГАЛАН I 1. гол мөрний урсгалын хажуугаас орж нийлэх усны нийлэлтийн газар; 2. нуур далайгаас гадагш гарсан нарийн горхи ус.

ЦУТГАЛАН II мал гөрөөсний зэрэг амьтны олгойн дунд хирээс салсан нарийн гэдэсний уг.

ЦУТГАЛЦАХ цутгахын үйлдэлцэх хэв.

ЦУТГАМАЛ төмөрлөгийн зүйлээр цутгаж хийсэн юм; *цутгамал шагаа; цутгамал шатар.*

ЦУТГАХ 1. гол мөрөн, далай нуурт хажуу этгээдээс нь орох усны нийлэх; *Орхонд Туул гол цутгана; Хараад Баян гол цутгадаг;* 2. бороонь сэггүй ургэлжлэн орох; *бороо цутгах;* 3. сав суулгаар ямар нэгэн юманд ус түрэн хийх: **асгах цутгах** хорш.; *нүхэнд ус цутгах; тариаланд ус цутгах;* 4. төмөрлөг ба лав зэргийн юмыг хайлуулж хэвэнд түрэх; *усэг цутгах; шатар цутгах; тэмдэг цутгах;* 5. бусдад хээл хахууль өгөх; *хээл цутгах; хахууль цутгах.*

ЦУТГУУЛАХ цутгахын үйлдүүлэх хэв.

ЦУТГУУР юм цутгадаг хэв, юм.

ЦУТГУУРЧ (ИН) төмөрлөгийн зүйлээр цутгаж урлах хүн; *цутгуурч дархан; цутгуурч уран.*

ЦУУ I хоолонд амт оруулах, бас идэшний зүйлийг дарж идэхэд хэрэглэх нэгэн зүйлийн исгэлэн шингэн зүйл; *цуунд дарах.*

ЦУУ II олны дунд тарсан эзэнгүй үг; *цуу үг; цуу тарах.*

ЦУУ III нэр, алдар; **нэр цуу, алдар цуу** х о р ш..

ЦУУ IV: цуу цуу ямааг дуудах аялгуу.

ЦУУ V хүч нэмэгдүүлэх үг; *цуу татах; цуу цохих.*

ЦУУВАЙ: цуувай цагаан цагаан өнгөтэй нэгэн зүйл хятад бараа.

ЦУУГИАН хэрүүл, маргаан; **үймээн цуугиан, хэрүүл цуугиан** х о р ш..

ЦУУГИЛ цуугиан.

ЦУУГИЛДАХ цуугихын үйлдүүлэх хэв. олноор цуугих; *та нар битгий цуугилдаад байгаарай.*

ЦУУГИЛДУУЛАХ цуугилдахын үйлдүүлэх хэв.

ЦУУГИНАЛДАХ цуугинахын үйлдүүлэх хэв, цуугилдах.

ЦУУГИНАХ цуугих.

ЦУУГИУЛАХ цуугихын үйлдүүлэх хэв.

ЦУУГИХ хэрэлдэх, тэмцэлдэх, маргалдах; шуугих ч гэдэг; **хэрэлдэх цуугих** х о р ш.; *учир зөвөө олж чадахгүй дэмий цуугих хэрэггүй.*

ЦУУДАМ юмыг ямагт хэтрүүлэн давуулж хэлэлцсэн үг яриа; *цуудам үг; цуудам яриа.*

ЦУУДАМЛАХ юмыг дэмий давуулж хэтрүүлэн хэлэлцэх.

ЦУУДАМНАХ цуудамлан хэлэлцэх.

ЦУУДАМНУУЛАХ цуудамнахын үйлдүүлэх хэв.

ЦУУДАМЧ хэтрүүлж давуулан хэлэлцэх зантай хүн.

ЦУУДАС юмнаас цуулж авсан хэсэг, зурвас юм; *модны цуудас; цуудас торго; цуудас бараа; цуудас утас; цуудас мод.* • • •

ЦУУДАСЛАХ цуудас болгох.

ЦУУЛАХ юмыг хагалан хувааж хэсэг хэсэг болгох; *үнь цуулах; эд бараа цуулах; мод цуулах.* •

ЦУУЛБАР юмнаас цуулж авсан хэсэг; *цуулбар бараа; цуулбар үнь; цуулбар мод;* **цуулбар им** (малын чихийг цуулж хийсэн нэгэн зүйл им).

ЦУУЛДАС цуудас.

ЦУУЛУУЛАХ цуулахын үйлдүүлэх хэв. •

ЦУУЛЬСДАХ 1. үйл явдлыг хянаж бодохгүй хийж хэлэлцсэнээс гэм буруу болох; 2. юмыг хир хэмжээнээс хэтрүүлэх цүүлсдэх ч гэдэг.

ЦУУР I нэгэн зүйл үлээвэр хөгжмийн зэвсэг, хэлбэр байдал нь лимбэтэй адил, цоор ч гэдэг.

ЦУУР II: **цуур өвс** у р г а м а л үхрийн хэл гэдэг ногоотой адил бөгөөд навч нь ширүүн, сундуутай, хүрэн цэцэгтэй нэг зүйл ногоо.

ЦУУРАЙ I дууриан; *хадны цуурай; уулын цуурай.*

ЦУУРАЙ II а м ь т а н бие хар, цагаан сэвхтэй, дуу ихтэй нэг зүйл бялзуухай.

ЦУУРАХ 1. юмны хагарч урагдах зэргээр ангайх, дарвайх; *дээл цуурч урагдах; авдар хагарч цуурах; гэрийн бүрээс цуурах; банз цуурах;* 2. юмыг хэтрүүлэн давуулж ярих, хэлэлцэх; *ам цуурах.*

ЦУУРГА 1. цүүд дарж торгох нүхтэй төмөр, даруулга ч гэдэг; 2. цоож; **цоож цуурга** х о р ш..

ЦУУРГАЛАХ 1. цуургыг цүүд оруулан дарж оньслох; **оньслох цуургалах** х о р ш.; 2. цоожлох: **цоожлох цуургалах** х о р ш..

ЦУУРГАЛУУЛАХ цуургалахын үйлдүүлэх хэв.

ЦУУРДАХ цуур хөгжмөөр хөгжимдөх, цоордох ч гэдэг.

ЦУУРДУУЛАХ цуурдахын үйлдүүлэх хэв.

ЦУУРУУЛАХ цуурахад хүргүүлэх.

ЦУУРХАЙ 1. юмны цуурсан газар; 2. хэтэрхий задгай амтай; *цуурхай амтай, хагархай хэнгэрэг шиг.*

ЦУУРХАЛ цуурхаж хэлэлцэх үйлийн нэр; *цуурхал гарах.*

ЦУУРХАХ 1. сайн муу нэр алдар гарч олноор цуугилцан шүүмжлэх; 2. олны дотор цуу үг тарах.

ЦУУРХУУЛАХ цуурхахын үйлдүүлэх хэв.

ЦУУТ I цуутай; *цуут эрдэмтэн; цуутын цагааеч гүү, цуурай цагаан унагатай* (үлгэрээс).

ЦУУТ II цуутай.

ЦУУТАЙ I сайн муу аль нэг талаар нэр гарч алдаршсан нь; *цуутай хүн; цуутай морь.*

ЦУУТАЙ II цуу бүхий, цуу найруулж хийсэн нь.

ЦУУХАЛ гүйцэд боловсрон идээ сууж чадаагүй үр тариа; *цуухал тариа; цуухал үр.*

ЦУУЦАЛЬ а м ь т а н зарагтай адилхан бөгөөд хушуу урт, сүүл охор, хөл өндөр нэг зүйл бялзуухай.

ЦУУЦУУЛАХ ямааг цуу цуу гэж дуудах.

ЦУУЧИХ байн байн цуулах, олонтоо цуулах.

ЦУУЯМБУУ хөвөн утсаар нэхсэн нэгэн зүйл бараа; *цууямбуу дээл.*

ЦУХАЛ I орон гэр, хувцас хунар, сав суулга зэргийн агуу тавиугүй, явцуу бага; *цухал цамц.*

ЦУХАЛ II 1. аливаа үйл хэргийн яаралтай бачим; 2. уурлаж хилэгнэх зан; *цухал ихтэй хүн.*

ЦУХАЛДАХ I сав суулга зэргийн юмны явцуудах.

ЦУХАЛДАХ II үйл ажилд маш мохож, тэсч ядан бачимдах; *дотор цухалдах.*

ЦУХАЛДУУЛАХ цухалдахын үйлдүүлэх хэв.

ЦУХАЛЗАХ 1. байн байн цухуйх; *тарвага нүхнээсээ цухалзаж харагдав;* 2. ш и л ж с э н хүний үйл явдлын сайн муу нь цухас илрэх; *гэм нь цухалзах; чадвартай нь нэг л цухалзаад байна шүү; гууль нь цухалзах; зэс нь цухалзах.*

ЦУХАЛЗУУЛАХ цухалзахын үйлдүүлэх хэв.

ЦУХАС товч төдий, цухуйх төдий, хагас нь; *цухас дурдах; цухас хэлэх; цухас мэдэгдэх;* **цухас цухас хийх** (байн байн түр цухуйх; *хулгана нүхнээсээ цухас цухас хийж байв).*

ЦУХАСХИЙХ түр ба гэнт цухуйх.

ЦУХУЙЛГАХ цухуйхын үйлдүүлэх хэв.

ЦУХУЙХ бяцхан ил гарах; *ногоо цухуйх; тарвага цухуйх; үг цухуйх; хэрэг цухуйх;* **зэс нь цухуйх, гууль нь цухуйх** (муу муухай нь илрэх).

ЦУЦАА I ядраа, цуцал.

ЦУЦАА II: **унаа цуцаа** унаа мал, унаа хөсөг.

ЦУЦААТАЙ цуцаа бүхий, ядраатай.

ЦУЦААХ цуцахад хүрүүлэх, цуцуулах.

ЦУЦАЛ I түлсэн модны нэг үзүүр нь шатаад, нөгөө үзүүр нь шатаагүй хоцорсон хэсэг; *галын цуцал; цуцал мод.*

ЦУЦАЛ II цуцах үйлийн нэр.

ЦУЦАЛГАХ 1. цуцлахад хүрүүлэх; 2. цуцлагдах.

ЦУЦАЛТ 1. цуцсан нь, эцэлт, ядралт; 2. буцалт, няцалт.

ЦУЦАЛТГҮЙ 1. эцэлтгүй, ядралтгүй; 2. буцалтгүй, няцалтгүй; *цуцалтгүй ажиллах; цуцалтгүй тэмцэх.*

ЦУЦАМХАЙ 1. алжаах цуцахдаа хялбар; 2. шантрамхай, няцамхай, буцамхай.

ЦУЦАРХАЙ 1. юмны цуцарсны нь; 2. цуцамхай.

ЦУЦАХ 1. алжаах мохох; **алжаах цуцах; эцэх цуцах** х о р ш.; 2. няцах, буцах.

ЦУЦАШГҮЙ 1. эцэшгүй, алжаашгүй; 2. няцашгүй, буцашгүй.

ЦУЦЛАГДАХ цуцлахын үйлдэгдэх хэв.

ЦУЦЛАХ I багласан боосон, байгуулсан бүтээсэн, тамсан сүлжсэн зэрэг юмыг задлах бутаргах, зудлах; *утас цуцлах; гэзэг цуцлах.*

ЦУЦЛАХ II гэрээ хэлэлцээр, харилцаа зэргийг хүчингүй болгох; *гэрээ цуцлах; дипломат харилцаагаа цуцлах.*

ЦУЦЛУУЛАХ 1. цуцлахын үйлдүүлэх хэв; 2. цуцлагдах.

ЦУЦРАХ аливаа юмны цуцархай болох, задрах, эвдрэх.

ЦУЦРАШГҮЙ цуцрах аргагүй, цуцрах шинжгүй.

ЦУЦРУУЛАХ цуцрахын үйлдүүлэх хэв.

ЦУЦЧИХ байн байн цуцлах, задлах.

ЦУЦЧУУЛАХ цуцчихын үйлдүүлэх хэв.

ЦҮГДГЭР хүний мөр далны орчим газар бөгцгөр.

ЦҮГДИЙЛГЭХ цүгдийхэд хүргүүлэх.

ЦҮГДИЙХ толгой бөхийлгөн гүйх, цүгдгэр болох.

ЦҮГДЭГНЭХ цүгдгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ЦҮГДЭЛЗЭХ цүгдгэр юмны байн байн хөдлөх.

ЦҮГДЭСХИЙХ түр зуур цүгдгэр болох.

ЦҮГЦРЭГ цүгцүүрэг.

ЦҮГЦҮҮРЭГ цүү төмөрт углах гогцоо төмөр, эр цүү ч гэдэг.

ЦҮЗГЭР 1. гэдэс хэвэл цурдгэр том; *цүзгэр гэдэстэй;* 2. зарим нэгэн юмны гадагш цүлхийж гарсны нь; *цүзгэр хэлбэртэй сав;* **цүзгэр хөрөө** (дунд хирээрээ гадагш цүлхгэр том хөрөө).

ЦҮЗГЭРДҮҮЛЭХ цүзгэрдэхийн үйлдүүлэх хэв.

ЦҮЗГЭРДЭХ хэтэрхий цүзгэр болох.

ЦҮЗИЙЛГЭХ цүзийхэд хүргүүлэх.

ЦҮЗИЙХ цүзгэр болох, цүзийж харагдах.

ЦҮЗЭГНҮҮЛЭХ цүзэгнэхийн үйлдүүлэх хэв.

ЦҮЗЭГНЭХ 1. цүзгэр юмны цүзэг цүзэг хөдлөх; 2. үйл ажилд тэвдэх, яарах, сандрах байдал гаргах.

ЦҮЗЭЛЗҮҮЛЭХ цүзэлзэхийн үйлдүүлэх хэв.

ЦҮЗЭЛЗЭХ 1. цүзгэр юмны цүзэс цүзэс хөдлөх; 2. яарч сандран тэвдэх, бачимдах.

ЦҮЛ: **цүл хийх** ус зэрэг ихээхэн шингэн юманд юмны унах чимээ гарах; *голын усанд том чулуу хаясанд цүл хийж дуугарав;* **цүл цал хийх** (а. их усаар гатлахад гарах дуу чимээ; б. хүний сал сул, задгай байдал гаргах); **цүл цүл хийх** (а. шингэн юмыг бүлэх зайлахад гарах чимээ; б. хүн амьтны яарч сандран мэгдэж гүйхий нь).

ЦҮЛХГЭР юмны аль нэгэн газрааараа гадагш цүзгэр байдалтайгий нь.

ЦҮЛХГЭРДҮҮЛЭХ цүлхгэрдэхийн үйлдүүлэх хэв, цүлхгэр болгох.

ЦҮЛХГЭРДЭХ хэтэрхий цүлхгэр болох.

ЦҮЛХИЙЛГЭХ цүлхийхэд хүргүүлэх.

ЦҮЛХИЙХ цүлхгэр болох, цүлхийж харагдах.

ЦҮЛХЭГНЭХ цүлхгэр юмны үргэлжлэн цүлхэг цүлхэг хөдлөх.

ЦҮЛХЭЛЗЭХ цүлхгэр юмны байн байн цүлхэс цүлхэс хөдлөх.

ЦҮЛЭГ 1. хэсэг бүлэг: **бүлэг цүлэг** х о р ш.; 2. аливаа нэгэн гэмт хэрэг үйлдэхэд нэгдсэн бүлэг хүмүүс.

ЦҮН: **цүн шаа** цүнчуутай адил бөгөөд ар гаргаж сиймхийвтэр нэхсэн нэгэн зүйл торгомсог эд.

ЦҮНДГЭР гэдэс хэвэл цэндгэр их.

ЦҮНДИЙЛГЭХ цүндийхэд хүргүүлэх.

ЦҮНДИЙХ цүндгэр болох, цүндийж харагдах.

ЦҮНДЭГНЭХ цүндгэр юмны үргэлжлэн цүндэг цүндэг хөдлөх.

ЦҮНДЭЛЗЭХ цүндгэр юмны **байн байн** цүндэс цүндэс хөдлөх.

ЦҮНХ юм хум агуулж хийх бяцхан сав; *цүнх барих.*

ЦҮНХГЭР түнхгэр, цүндгэр, цүлхгэр.

ЦҮНХГЭРДҮҮЛЭХ цүнхгэрдэхийн үйлдүүлэх хэв.

ЦҮНХГЭРДЭХ хэтэрхий цүнхгэр болох.

ЦҮНХИЙ: **цүнхий цэцэг** у р г а м а л гавирын цэцэгтэй адил, таван хэлтэстэй, хавар эрт цэцэглэдэг, өвөл шарлахгүй нэгэн зүйл цэцэг.

ЦҮНХИЙЛГЭХ цүнхийхэд хүргүүлэх.

ЦҮНХИЙХ цүнхгэр болох, түнхийх.

ЦҮНХЭЭЛ усны эргэлдсэн гүн газар; *цүнхээл ус.*

ЦҮНЧҮҮ панстай адил бөгөөд нягтхан нэхээстэй нэгэн зүйл торгомсог эд.

ЦҮРГЭР хүн амьтны гэдэс хэвэл цүзгэр, цэрдгэрий нь.

ЦҮРГЭРДҮҮЛЭХ цүргэрдэхийн үйлдүүлэх хэв.

ЦҮРГЭРДЭХ хэтэрхий цүргэр болох.

ЦҮРДГЭР цүргэр, түсгэгэр.

ЦҮРДГЭРДҮҮЛЭХ цүрдгэрдэхийн үйлдүүлэх хэв.

ЦҮРДГЭРДЭХ хэтэрхий цүрдгэр болох.

ЦҮРДИЙЛГЭХ цүрдийхэд хүргүүлэх.

ЦҮРДИЙХ цүрдгэр болох, цүрдийж харагдах.

ЦҮРДЭГНҮҮЛЭХ цүрдэгнэхийн үйлдүүлэх хэв.

ЦҮРДЭГНЭХ цүрдгэр юмны цүрдэг цүрдэг хөдлөх.

ЦҮРДЭЛЗҮҮЛЭХ цүрдэлзэхийн үйлдүүлэх хэв.

ЦҮРДЭЛЗЭХ цүрдгэр юмны цүрдэс цүрдэс хөдлөх.

ЦҮРИЙЛГЭХ цүрийхийн үйлдүүлэх хэв.

ЦҮРИЙХ цүргэр болох, цүрийж харагдах.

ЦҮРЭГНЭХ цүргэр юмны цүрэг цүрэг хөдлөх.

ЦҮРЭЛЗЭХ цүргэр юмны цүрс цүрс хөдлөх.

ЦҮҮ I цүгцүүрэгт торгох төмөрлөг, эм цүү ч гэдэг.

ЦҮҮ II: **цүү хаях** шөнийн цагт хоёр барим хэмжээний модыг шидэж түүнийг эрэн олж булаалдан тэмцэлдэх нэгэн зүйл тоглоом, цагаан мод хаях ч гэдэг; ☆ **цүү гадас** (тэрэгний арлын гуяны өмнөх үзүүрт босгож хийх мод).

ЦҮҮВЭН түрээс; *цүүвэн хураах.*

ЦҮҮВЭНГЭ амсар ба ёроол нь хумгар, дундуураа цүлхгэр хэлбэртэй тогоо.

ЦҮҮЛҮҮЛЭХ цүүлэхийн үйлдүүлэх хэв.

ЦҮҮЛЭХ I цүүг цүгцүүрэгт дарж торгох; *үүдээ цүүлэх; авдраа цүүлэх.*

ЦҮҮЛЭХ II бусдыг мууд тулгуулах.

ЦҮҮРГЭР цүүцгэр.

ЦҮҮРГЭРДҮҮЛЭХ цүүргэрдэхийн үйлдүүлэх хэв.

ЦҮҮРГЭРДЭХ хэтэрхий цүүргэр болох.

ЦҮҮРИЙЛГЭХ цүүрийхэд хүргүүлэх.

ЦҮҮРИЙХ цүүргэр болох, цүүцийх.

ЦҮҮРЭГНЭХ цүүргэр юмны цүүрэг цүүрэг хөдлөх.

ЦҮҮРЭЛЗЭХ цүүргэр юмны цүүрс цүүрс хөдлөх.

ЦҮҮЦ мод зэрэг юмыг нүхлэх, цоолоход цохиж ухах нэг зүйл багаж.

ЦҮҮЦГЭР юмны нарийн, хэврэг туя мууТайгий нь; *цүүцгэр хөлтэй ширээ; цүүцгэр нарийн үнь.*

ЦҮҮЦГЭРДҮҮЛЭХ цүүцгэрдэхийн үйлдүүлэх хэв.

ЦҮҮЦГЭРДЭХ хэтэрхий цүүцгэр болох.

ЦҮҮЦДҮҮЛЭХ цүүцдэхийн үйлдүүлэх хэв.

ЦҮҮЦДЭХ цүүцээр юмыг ухаж нүх гаргах.

ЦҮҮЦИЙЛГЭХ цүүцийхэд хүргүүлэх.

ЦҮҮЦИЙХ цүүцгэр болох.

ЦҮҮЦЭГНЭХ цүүцгэр юмны цүүцэг цүүцэг хөдлөх.

ЦҮҮЦЭЛЗЭХ цүүцгэр юмны цүүцэс цүүцэс хөдлөх.

ЦЭВ хүч нэмэгдүүлэх үг; *цэв цэвэр; цэв цэнхэр; цэв цэгээн; цэв хүйтэн.*

ЦЭВДЭГ 1. их л хөлдүү; *цэвдэг газар; цэвдэг хөлдүү; цэвдэг хөрс;* **цэвдэг судлал** (мөнх ба мөнх биш цэвдгийн тархалт, үүсч бий болсон нөхцөл шалтгааныг судлах ухаан); **мөнх цэвдэг** (газрын хөрсөн дор гүн орших мөнхийн хөлдүү давхрага); 2. ш и л ж с э н аливаа үйл явдалд хүнийрхүү хүйтэн сэтгэлээр хандах хандлага; *цэвдэг сэтгэлээр хандах.*

ЦЭВДЭГДЭХ хэтэрхий цэвдэг болох.

ЦЭВДЭГРҮҮЛЭХ цэвдэгрэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭВДЭГРЭХ цэвдэг болох.

ЦЭВДЭГТҮҮЛЭХ цэвдэгтэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭВДЭГТЭХ цэвдэгтэй болох.

ЦЭВДЭГШИХ цэвдэгрэх, цэвдэг шинжтэй болох.

ЦЭВДЭГШҮҮЛЭХ цэвдэгшихийн үйлдүүлэх хэв.

ЦЭВРҮҮ түлэгдэх, холгох, хөлдөх зэрэг шалтгаанаас арьсанд бий болох устай гүвдрүү, цөврүү ч гэдэг; **цэврүү үсрэх** (цэврүү гарах, цэврүү бий болох).

ЦЭВРҮҮТҮҮЛЭХ цэврүүтэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭВРҮҮТЭХ цэврүү үсрэх, цэврүү гарах; *гар цэврүүтэх.*

ЦЭВЦГЭР нав цайм юм; *цэвцгэр цагаан; цэвцгэр өөх.*

ЦЭВЦИЙЛГЭХ цэвцийхийн үйлдүүлэх хэв.

ЦЭВЦИЙХ цэвцгэр болох.

ЦЭВЦЭГНЭХ цэвцгэр юмны цэвцэг цэвцэг хөдлөх.

ЦЭВЦЭЛЗЭХ цэвцгэр юмны цэвцэс цэвцэс хөдлөх.

ЦЭВЭР 1. хир тоос, бузар буртаггүй ариун; **цэвэр цээр** х о р ш.; *цэвэр айл; цэвэр аяга; цэвэр агаар; цэвэр хувцсаа өмсөх;* **ариун цэвэр** (хүн амын эрүүл мэнд болон нийт олныг цэвэр боловсон байлгах арга хэмжээ; *хувийн ариун цэвэр; ариун цэврийн шаардлагыг биелүүлэх);* **цэвэр ус** (бохир муухай биш ус); 2. юмны хийсэн, бүтсэн байдал янз үзэмжтэй, аятай; *цэвэр оёх;* **цэвэр хийх** (юмыг сайн сайхан, аятай, үзэмжтэй үйлдэх); **цэвэр царай** (аятайхан, сайхан, үзэмжтэй царай зүс); 3. үнэнч, шударга: **цэвэр ичимтгий** (сахилга журам сайн, явдал үйл шударга, санаа үнэнч хүн); **цэвэр явдал** (ариун, шударга, үнэн үйлс); ☆ **цэвэр ашиг** (бүх зардал сүйтгэлийг нөхөөд илүүдэж үлсэн хувь).

ЦЭВЭРЛҮҮЛЭХ 1. цэвэрлэхийн үйлдүүлэх хэв; 2. цэвэрлэгдэх.

ЦЭВЭРЛЭГДЭХ цэвэрлэхийн үйлдэгдэх хэв.

ЦЭВЭРЛЭГЧ цэвэрлэх үүрэг бүхий этгээд; *цэвэрлэгчийн орон тоог нэмэх.*

ЦЭВЭРЛЭЛ цэвэрлэх үйлийн нэр.

ЦЭВЭРЛЭЛЦЭХ цэвэрлэхийн үйлдэлцэх хэв.

ЦЭВЭРЛЭХ цэвэр ариун болгох; *нэрээ цэвэрлэх; гэр орноо цэвэрлэх; ус цэвэрлэх; хувцас цэвэрлэх; гудамж цэвэрлэх.*

ЦЭВЭРХЭН цэвэр, ариун, гуа, сайхан; *Зэгст нуурын зах дээр, цэвэрхэн халиун морь минь, цэгцхэн зангаар өсгөлөн, аав эжий хоёр минь* (ардын дуу).

ЦЭВЭРЧ хүний ариун цэвэр, үзэмжтэй, аятай сайхан байх заншилтайгий нь; *цэвэрч хүн; цэвэрч хүүхэд.*

ЦЭВЭРШИХ цэвэр ариун болох, цэвэр шинжтэй бо.ох.

ЦЭВЭРШҮҮЛЭХ цэвэршихийн үйлдүүлэх хэв.

ЦЭГ I хүүрнэх, захирах өгүүлбэрийн эцэст тавих нэг зүйл тэмдэг; **гурван цэг** (өгүүлбэрийг ямар нэгэн шалтгаан учраас төгсгөөгүй тасалсан буюу нэг юмыг хэлэх гэж байтал хэлэхээ больж өөр юманд орсон зэргийг заахад тавих цэг); **давхар цэг** (аливаа юмыг тоочиход тавих хоёр цэг); **цэг таслал** (нийлмэл өгүүлбэрийн доторхи өгүүлбэрийн эцэст тавих цэгтэй таслал).

ЦЭГ II шагааны гэдрэгэн этгээд тал; *буг цэг няслах.*

ЦЭГДЭГ дээлийн дотуур өмсөх хөвөнтэй охор хувцас; *цэгдэг хүрэм.*

ЦЭГЛҮҮЛЭХ цэглэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭГЛЭЛ өгүүлбэрт хэрэглэх цэг тэмдэг; *цэг цэглэлийн учир.*

ЦЭГЛЭХ 1. цэг тавих, цэгтэй болгох; 2. ш и л ж ө э н зогсох, болих, завсарлах; *ажлаа цэглэх; яриагаа цэглэх.*

ЦЭГНҮҮЛЭХ цэгнэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭГНЭХ цэгнүүр хэмжүүрээр хэмжих, цэннэх.

ЦЭГСЭН: цэгсэн жимс у р г а м ал өнгө шар, дотроо оогийн адил цагаан юмтай нэгэн зүйл ногоо.

ЦЭГЦ 1. хүний үг ухаан тодорхой товтойг нь; **эрс цэгц, шулуун цэгц, шудрага цэгц** х о р ш.; 2. эгц, шулуун; *цэгц мод; цэгц сайхан уурга;* 3. юмны эмх замбараатайгий нь; **эмх цэгц** х о р ш..

ЦЭГЦГЭР хүн амьтны бие ба байдал явхийн төрсөн бөгөөд гавшгай сэргэлэн.

ЦЭГЦДЭХ хэтэрхий цэгц болох, эгцдэх.

ЦЭГЦЛҮҮЛЭХ 1. цэгцлэхийн үйлдүүлэх хэв; 2. цэгцлэгдэх.

ЦЭГЦЛЭГДЭХ цэгцлэхийн үйлдэгдэх хэв.

ЦЭГЦЛЭЛЦЭХ цэгцлэхийн үйлдэлцэх хэв.

ЦЭГЦЛЭХ юмыг цэгцтэй журамтай, эмхтэй болгох, цэгцтэй болгох; *хурааллтай номоо цэгцлэх.*

ЦЭГЦРҮҮЛЭХ цэгцрэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭГЦРЭХ цэгц болох, журамтай болох, эмхтэй болох.

ЦЭГЦСЭХ цэгцтэх.

ЦЭГЦТЭЙ эмх цэгц сайтай; *цэгцтэй болгох.*

ЦЭГЦТЭХ улмаар цэгц болох.

ЦЭГЦЭСГЭХ цэгцсэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭГЦЭТГЭХ цэгцтэхэд хүргүүлэх.

ЦЭГЭЭ гүүний айраг; **айраг цэгээ** х о р ш..

ЦЭГЭЭН цагаан: **цагаан цэгээн, цэгээн бүгээн** х о р ш.; **цэгээн шаваг** у р г а м а л (хужир мараатай газар ургадаг нэг зүйл шаваг); **цэгээн шарилж** у р г а м а л (10—15 сантиметр өндөр ургадаг нэг зүйл шарилж, хуурайвтар хөрстэй газар ургана, өвлийн цагт малд тэжээлтэй).

ЦЭГЭЭХЭН арай цэгээн, нилээд цэгээн.

ЦЭДГЭР цэзгэр, цүдгэр.

ЦЭДИЙЛГЭХ цэдийхэд хүргүүлэх.

ЦЭДИЙХ цэдгэр болох.

ЦЭДЭГНЭХ цэдгэр юмны цэдэг цэдэг хөдлөх.

ЦЭДЭЛЗЭХ цэдгэр юмны цэдэс цэдэс хөдлөх.

ЦЭЖМЭГ ан амьтны арьсаар хийсэн олбог.

ЦЭЗГЭР хүн амьтны бие хэгэрхий бага болоод махлаг буюу ахиад байдалтайгий нь; *цэзгэр биетэй хүүхэд; цэзгэр хурга.*

ЦЭЗИЙЛГЭХ цэзийхийн үйлдүүлэх хэв.

ЦЭЗИЙХ цэзгэр болох.

ЦЭЗЭГНЭХ цэзгэр юмны цэзэг цэзэг хөдлөх.

ЦЭЗЭЛЗЭХ цэзгэр юмны цэзэс цэзэс хөдлөх.

ЦЭЛ хүч нэмэгдүүлэх үг; **цэл ногоон** (нов ногоон); **цэл хүйтэн** (хөв хүйтэн); **цэл хөх** (хөв хөх); **цэл буурал** (бүв буурал); **цэл залуу** (хүн амьтны чухам идэр насны үе).

ЦЭЛБЭН: цэлбэн цагаан маш цагаан, улцан цагаан.

ЦЭЛГЭР саруул, уужим, зайтай юм; *цэлгэр нутаг; цэлгэр тал хөндий; цэлгэр зайтай гэр; цэлгэр байшин.*

ЦЭЛГЭРДҮҮЛЭХ цэлгэрдэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭЛГЭРДЭХ хэтэрхий цэлгэр болох.

ЦЭЛДЭН юмны зүсэм өнгө тодотгоход хэрэглэх үг; *цэлдэн хөх гурил; цэлдэн хар царай; цэлдэн бор нүүр.*

ЦЭЛИЙЛГЭХ цэлийхэд хүргүүлэх.

ЦЭЛИЙХ цэлгэр болох.

ЦЭЛМҮҮЛЭХ цэлмэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭЛМҮҮН саруул, цэлмэг.

ЦЭЛМЭГ 1. тэнгэр үүл манангүй, тунгалаг; *тэнгэр цэлмэг сайхан байна; цэлмэг өдөр; цэлмэг шөнө; цэлмэг тэнгэр;* 2. саруул; *цэлмэг ухаантай хүн.*

ЦЭЛМЭН цэмбэний үс; *цэлмэн цэмбэ.*

ЦЭЛМЭНТЭЙ цэлмэн бүхий.

ЦЭЛМЭХ бүрхсэн тэнгэр гийж, үүл манангүй цэвэрхэн болох; *тэнгэр цэлмэх.*

ЦЭЛХЭЛЗҮҮЛЭХ цэлхэлзэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭЛХЭЛЗЭХ цэлцэлзэх.

ЦЭЛЦГИЙ мах, хуйх зэргийг шалзартал буцалгаад царцааж хийсэн нэг зүйл идээ.

ЦЭЛЦГЭР тарган, цулцгар; *цэлцгэр хацар; цэлцгэр гэдэс; цэлцгэр өвх.*

ЦЭЛЦГЭРДЭХ хэтэрхий цэлцгэр болох.

ЦЭЛЦИЙЛГЭХ цэлцийхэд хүргүүлэх.

ЦЭЛЦИЙХ цэлцгэр болох.

ЦЭЛЦЭГНҮҮЛЭХ цэлцэгнэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭЛЦЭГНЭХ цэлцгэр юмны цэлцэг цэлцэг хөдлөх, цэлэгнэх.

ЦЭЛЦЭЛЗҮҮЛЭХ цэлцэлзэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭЛЦЭЛЗЭХ цэлцгэр юмны цэлцэс цэлцэс хөдлөх, цэлхэлзэх.

ЦЭЛЭГ морины тэмүүлэх зантайгий нь; *цэлэг морь.*

ЦЭЛЭГНҮҮЛЭХ цэлэгнэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭЛЭГНЭХ цэлгэр юмны цэлэг цэлэг хөдлөх.

ЦЭЛЭЛЗҮҮЛЭХ цэлэлзэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭЛЭЛЗЭХ 1. цэлгэр юмны цэлс цэлс хөдлөх; 2. цэлгэр зайтай юмны уужим саруул байгаа байдал; *цэлэлзсэн сайхан байшин; цэлэлзсэн том тасалгаатай өрөө; цэлэлзсэн тал нутаг;* 3. шингэн юмны мэлтэлзэн бялхаж хөдлөх; *хул дүүрэн цэлэлзсэн айраг өгөв; хувин дүүрэн сүү цэлэлзэн бялхаж байв; цэлэлзсэн их ус.*

ЦЭЛЭМ нэг зүйл цэмбэ.

ЦЭМБИЙЛГЭХ цэмбийхэд хүрүүлэх.

ЦЭМБИЙХ цэмбэгэр болох.

ЦЭМБЭ (Н) нэгэн зүйл зузаан ноосон нэхмэл бараа; *цэмбэн дээл;* **цэмбэний фабрик** (цэмбэ үйлдвэрлэх үйлдвэр); **хятад цэмбэ** (төвд цэмбэтэй адилавтар нэг зүйл бүдүүлэг бөс); **орос цэмбэ** (одончуу) **төвд цэмбэ** (няг нэхээстэй, хоёр талдаа үсэрхэг байдалтай, нарийн энтэй нэгэн зүйл цэмбэ); **тал цэмбэ** (даавуу артай, өнгөн тал нь үсэрхэг нэг зүйл бөс).

ЦЭМБЭГНЭХ цэмбэгэр юмны үргэлжлэн хөдлөх, сэмбэгнэх.

ЦЭМБЭГЭР 1. цэмцгэр, үзэмжтэй, цэвэрч; *цэмбэгэр сайхан айл;* 2. ганган, гоёмсог; *цэмбэгэр хүн.*

ЦЭМБЭЛЗЭХ цэмбэгэр хүний байн байн хөдлөх, сэмбэлзэх.

ЦЭМБЭЛҮҮЛЭХ цэмбэлэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭМБЭЛЭХ юмыг цэмбэтэй болгох, цэмбээр бүрэх; *ширээ цэмбэлэх.*

ЦЭМБЭЧ (ИН) цэмбэ хийдэг мэргэжилтэй хүн.

ЦЭМЦГЭР 1. цэвэрч, цээрч; 2. гоёмсог, ганган байдалтай.

ЦЭМЦГЭРДЭХ хэтэрхий цэмцгэр болох.

ЦЭМЦИЙЛГЭХ цэмцийхэд хүрүүлэх.

ЦЭМЦИЙХ цэмцгэр болох.

ЦЭМЦЭГНҮҮЛЭХ цэмцэгнэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭМЦЭГНЭХ цэмцгэр юмны цэмцэг цэмцэг хөдлөх.

ЦЭМЦЭЛЗҮҮЛЭХ цэмцэлзэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭМЦЭЛЗЭХ цэмцгэр юмны цэмцэс цэмцэс хөдлөх.

ЦЭН хүндийн хэмжээ, арван пун, дөрвөн граммтай тэнцэнэ; *хоёр цэнгийн бөгж.*

ЦЭНГҮҮЛЭХ цэнгэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭНГЭГ огт давсгүй буюу давс багатай ус; *цэнгэг усанд амьдрах загас.*

ЦЭНГЭЛ санаанд тавтайяа нийлэлцэж баяр лах, жаргах үйлийн нэр; **баяр цэнгэл, жаргал цэнгэл** х о р ш.; *цэнгэл эдлэх;* **цэнгэл хийх** (цэнгэх үйл үйлдэх); **цэнгэлт цэцэг** у р г а м а л (иш ба цэцгийн өнгө харавтар улаан, намар өвлийн хяруунд боловч өнгө гутахгүй нэгэн зүйл ургамал).

ЦЭНГЭЛДҮҮЛЭХ цэнгэлдэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭНГЭЛДЭХ 1. баяр цэнгэл хийх; 2. олноороо цэнгэх үйл хийх, зугаалах.

ЦЭНГЭХ наадах, баясах, жаргах, зугаалах; *наадаж цэнгэх; баясч цэнгэх; жаргаж цэнгэх.*

ЦЭНДГИЙ а м ь т а н өнгө ногоон, бие маш бяцхан нэг зүйл бялзуухай.

ЦЭНДГЭР амьтны гэдэс хэвэл ихтэйгий нь; *цэндгэр гэдэс; цэндгэр харвин.*

ЦЭНДИЙЛГЭХ цэндийхийн үйлдүүлэх хэв.

ЦЭНДИЙХ цэндгэр болох.

ЦЭНДЭГНЭХ цэндгэр юмны цэндэг цэндэг хөдлөх.

ЦЭНДЭЛЗЭХ цэндгэр юмны цэндэс цэндэс хөдлөх.

ЦЭНЛҮҮР дэнс хэмжүүр.

ЦЭНЛЭХ цэнлүүрээр хэмжих, цэгнэх.

ЦЭНХГЭР юмны өнгө зэвгэр барагтайхныг нь, цонхигор ч гэдэг; *цэнхгэр царайтай хүн; цэнхгэр өнгөтэй эд.*

ЦЭНХИЙХ 1. цэнхгэр болох, цийлийх; 2. зэвхий хөөнгө царайтай болох.

ЦЭНХЭР цагаавтар хөх өнгө; *хөрст алтан дэлхийн хөвөө хязгаар нутагт, хөх цэнхэр далайн эрэг ирмэг газарт* (Алтан загасны үлгэрээс).

ЦЭНХЭРДҮҮЛЭХ цэнхэрдэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭНХЭРДЭХ хэтэрхий цэнхэр болох.

ЦЭНХЭРЛҮҮЛЭХ цэнхэрлэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭНХЭРЛЭХ цэнхэр болгох, цэнхэр өнгөтэй харагдах; *цэнхэрлэн харагдах уул.*

ЦЭНХЭРТҮҮЛЭХ цэнхэртэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭНХЭРТЭХ улмаар цэнхэр болох, хөхөрч харагдах; *агаар цэнхэртэж үзэгдэх; ус цэнхэртэх; ургамал цэнхэртэх.*

ЦЭНЭГ бууны суманд тодорхой хэмжээтэй хийсэн тэсрэх бодис; *цэнэг бухий буу;* **цахилгаан цэнэг** (тухайн биед бий цахилгааны хэмжээ); **эерэг цэнэг, эерэх цэнэг** (цахилгааны нэмэх цэнэг); **сөрөг цэнэг, сөрөх цэнэг** (цахилгааны хасах цэнэг).

ЦЭНЭГЛҮҮЛЭХ цэнэглэхийн үйлдүүлэх хэв; *галын хор цэнэглүүлэх.*

ЦЭНЭГЛЭЛ цэнэглэх үйлийн нэр.

ЦЭНЭГЛЭХ сум зэрэг тэсрэх дэлбэрэх зүйлийг цэнэгтэй болгох; *буу цэнэглэх; гар чийдэн цэнэглэх; галын хор цэнэглэх.*

ЦЭНЭГТЭЙ цэнэг бүхий; *цэнэгтэй буу; цэнэгтэй хор.*

ЦЭНЭХ үйл ажилд урьдаас хаширлаж болгоомжлох, анах; **анах цэнэх** х о р ш.; *болгоомжилж цэнэх; хаширлаж цэнэх; хардаж цэнэх; манаж цэнэх.*

ЦЭР I хүн амьтны уушиг болон хоолойгоос гарах налдаа зүйл; *цустай цэр гарах.*

ЦЭР II: **цэр цэр хийх** юмны цар цар хийж дуугарах.

ЦЭРВҮҮ юманд халдан ойртож чадахгүй холхон буюу дөнгөж хүрэлцэх төдий байхы нь: *цэрвүү хөл; цэрвүү барих; цэрвүү барилдах.*

ЦЭРВҮҮДҮҮЛЭХ цэрвүүдэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭРВҮҮДЭХ хэтэрхий цэрвүү болох.

ЦЭРВЭГ цэрвүү.

ЦЭРВЭГДЭХ хэтэрхий цэрвэг болох, цэрвүүдэх.

ЦЭРВЭЛЗЭХ тариа ногоо зэрэг юмны найгаж ганхан хөдлөх.

ЦЭРВЭХ юмнаас халдан барьж чадахгүй хойргоших, зайлсхийх, ойртож чадахгүй байх.

ЦЭРД бичих зурах зэрэгт хэрэглэх зөөлөн шохой; *цэрдээр самбар дээр бичих.*

ЦЭРДГЭР амьтны гэдэс хэвэл цондгор ба бие нэндүү жижгий нь.

ЦЭРДИЙЛГЭХ цэрдийхийн үйлдүүлэх хэв.

ЦЭРДИЙХ цэрдгэр болох.

ЦЭРДЭГНЭХ цэрдгэр юмны үргэлжлэн цэрдэг цэрдэг хөдлөх.

ЦЭРДЭЛЗЭХ цэрдгэр юмны байн байн цэрдэс цэрдэс хөдлөх.

ЦЭРМҮҮЛЭХ цэрмэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭРМЭХ морь малын цас цавчлах.

ЦЭРЦГЭР дорой яданги байдалтай; *цэрцгэр хүүхэд; цэрцгэр туеал.*

ЦЭРЦИЙЛГЭХ цэрцийхэд хүрүүлэх.

ЦЭРЦИЙХ хүйтнээс буюу бороо усанд норсноос болж бие маш ихээр даарах; *ус бороонд цэрцийх.*

ЦЭРЦЭГНЭХ цэрцгэр юмны үргэлжлэн хөдлөх.

ЦЭРЦЭЛЗЭХ цэрцгэр юмны байн байн хөдлөх.

ЦЭРЭВ өндөр юмнаас дээгүүр тэлж татсан хэц зэл; **хэц цэрэв, зэл цэрэв** х о р ш.; **цэрэв татах** (хэц зэл татах).

ЦЭРЭГ 1. улсын зэвсэгт хүчин; *хуурай замын цэрэг; усан замын цэрэг; Ардын цэрэг; морин цэрэг; алтан үсэгтэй захидлыг, амраг чамдаа бичлээ дээ, Ардын цэргийн албанд, амар мэнд байна уу даа* (дуу); **Ардын журамт цэрэг** (ардын хувьсгалыг байгуулах үйл хэрэгт оролцож явсан сайн дурын цэрэг); **сайн дурын цэрэг** (жинхэнэ цэрэгт туслах зорилгоор сайн дураараа элсэж нэгдсэн цэрэг); **цэрэг элсэх, цэрэгт элсэх** (армид сайн дураараа элсэн орох); **цэрэг татлага** (армид хүмүүсийг дайчлан албан хаалгах арга хэмжээ); **цэрэг татах, цэрэг дайчлах** (армид зохих насны хүмүүсийг дайчилж албан хаалгах); **цэрэгт мордох, цэрэгт явах** (армийн албанд явах); **цэргийн тангараг** (цэргийн албанд үнэнч шударга зүтгэхийг батлан өгөх тангараг); **цэргийн сахилга** (цэргийн дүрэмд заасан журам сахилга); **цэргийн бүртгэл** (цэргийн насны хүмүүст тусгайлан олгох үнэмлэх дэвтэр); **цэргээс халагдах, цэргээс буух** (тайван цагт буюу өөр шалтгаанаар цэргийн албанаас хүмүүсийг халах); **цэргийн бэлтгэл** (цэргийн хэрэглэхүүнийг хангаж нийлүүлэх албаны газар); **цэргийн хувцас** (цэргийн албан хаагч-

дад өмсгөх дүрэмт хувцас); **цэргийн анги** (цэргийн бүлэг, нэгдэл); **цэргийн сургууль** (цэргийн алив мэрэгжилд сургах сургууль); **цэргийн эмч** (армийн албан хаагчдыг эмчлэх эмч); **цэргийн эмнэлэг** (армийн албан хаагчдад үйлчлэх эмнэлэг); **цэргийн шүүх** (цэргийн албан хаагчдын өдүүлсэн гэмт хэргийг таслан шийтгэх шүүх); **цэргийн үйлдвэр** (цэргийн зэвсэг техник, хэрэглэл зэргийг үйлдвэрлэх үйлдвэр); **цэргийн хэлтэс** (орон нутгийн захиргааны төвлөх байгууллагуудад цэргийн тухай хэргийг эрхлэх хэлтэс); **цэргийн бааз** (цэргийг төвлөрүүлэн суулгасан газар; *гадаадын цэргийн бааз);* 2. улсын зэвсэгт хүчинд байлдагчийн албан тушаалтай хүн; *дарга цэрэг хэн боловч цэргийн төмөр мэт сахилга батыг сахих хэрэгтэй.*

ЦЭРЭГЖИЛ цэргийн мэрэгжилд сургах үйлийн нэр; *цэрэгжлийн хичээл.*

ЦЭРЭГЖИХ 1. цэрэгтэй болох; 2. цэргийн мэрэгжилтэй болох.

ЦЭРЭГЖҮҮЛЭХ цэрэгжихийн үйлдүүлэх хэв.

ЦЭРЭГЛЭЛ цэрэглэх үйлийн нэр.

ЦЭРЭГЛЭХ бусдыг цэргээр дайран довтлох.

ЦЭРЭГШИЛ цэрэгших үйлийн нэр.

ЦЭРЭГШИХ цэргийн шинжтэй болох.

ЦЭС I у р г а м а л өнгө хар, янз бөөрөнхий, буцалган дарж идвэл болдог нэгэн зүйл ногоо.

ЦЭС II албаны хэрэг зүйлийг жагсаан бүртгэж товхисон дэвтэр; *цэргийн цэс; нэрсийн цэс; цалингийн цэс.*

ЦЭСЧҮҮ нэгэн зүйл торгомсог эд, чисчүү ч гэдэг.

ЦЭХ 1. эгц, шулуун, чиг; *цэх харах; цэх зогсох; цэх явах; цэх зам; цэх шугам;* 2. ш и л ж с э н шудрага; цэх **шудрага** х о р ш.; *цэх хүн.*

ЦЭХЛҮҮЛЭХ цэхлэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭХЛЭХ цэх болгох, эгц болгох, шулуун болгох.

ЦЭХЧ төв шудрага, голч.

ЦЭХЭР юмны өнгө цэгээний нь; *цэхэр өнгөтэй; цэхэр нүдтэй; цэхэр шил.*

ЦЭЦ 1. юмны онч; *цэц булаалдах; цэц харвах; цэц хэлэлцэх;* 2. буу зэвсгийн зорьсон газартаа онож тусахдаа сайны нь; *буугны цэц үзэх.*

ЦЭЦГИЙ нүдний солонгон бүрхэвчийн гэрэл нэвтрэн орох гол; *нүдний цэцгий.*

ЦЭЦЛЭГ цэх.

ЦЭЦЛЭХ цэц булаалдах, цэц ярих.

ЦЭЦЭГ I 1. ногоон цоморлигоос дэлгэрэн гарсан хэлтэс дэлбээс бүтэх үржлийн эрхтэн, бас ийм эрхтэн бүхий ургамал; *цэцэг тарих; цэцэг ургуулах; цэцэг түүх; цонхон дээр цэцэг байна, ургаа цэцгээ усалж байя* (дуу); **цэцэг дэлгэрэх** (цэцгийн тоорцог дэлбэрэн цэцэглэх); **цэцгийн хэлтэс** (цэцгийн тойрсон салаанууд): **цэцгийн хүйс** (а. цэцгийн төв дундах дүгрэг хэсэг; б. цэцгийн нэг бүхэл хэсэг); **цэцгийн тоорцог** (цэцгийн дотоод саглагар); **цэцгийн дэлбэ** (цэцгийн хэлтэс); **цэцгийн дугтуй** (цэцгийн цоморлигийн хальс); **цэцгийн цоморлиг** (цэцгийн дэлбэрч дэлгэрээгүй бөөм); **цэцгийн сав** (цэцгийн тарьж ургуулсан сав); **цэцгийн баглаа** (цэцгийг сонгон авч, хүнд барих зэрэгт хэрэглэхээр бөөгнөрүүлсэн нь; *амьд цэцгийн баглаа барив);* **цэцгийн хүлэмж** (цэцэг ургамлыг тарьж ургуулахын тулд бэлтгэсэн дулаан байр): **цэцгийн хүрээ** (цэцгийн хүрээлэн); **цэцгийн хүрээлэн** (цэцгийг тарьж ургуулсан газар); ☆ **хөзрийн цэцэг** (хөзрийн цэцэг хэлбэртэй дүрс); 2. хүн малын нүүр, чих хоолой зэрэгт ургасан бяцхан зүйл; *чихний цэцэг;* 3. эр тахианы толгой дээрх мах мэт улаан юм; *тахианы цэцэг.*

ЦЭЦЭГ II 1. их зэрэг сувилах өвчин, цагаан бурхан, бодоо ч гэдэг; 2. бог малд тохиолдох нэгэн зүйл өвчин.

ЦЭЦЭГЛҮҮЛЭХ цэцэглэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭЦЭГЛЭГ ургамал ногоо, цэцэг үлэмж сайхан газар.

ЦЭЦЭГЛЭЛТ 1. цэцгийн ургах явц; 2. алив юмны хөгжлийн шат; *манай орны соёлын цэцэглэлт.*

ЦЭЦЭГЛЭХ 1. цэцэг дэлгэрэн дэлбэрэх; *цэцэг цэцэглэх; мод цэцэглэх;* 2. хөгжих, дэвших; *Эх орон минь цэцэглэн хөгжсөөр байна.*

ЦЭЦЭГТ цэцэг бүхий; *цэцэгт ургамал.*

ЦЭЦЭГТҮҮЛЭХ цэцэгтэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭЦЭГТЭЙ цэцэг бүхий, цэцэгт; *цэцэгтэй уул; цэцэгтэй мод.*

ЦЭЦЭГТЭХ I ургамлын цэцэг цэцэглэх.

ЦЭЦЭГТЭХ II хүн малд цэцэг өвчин тохиолдох.

ЦЭЦЭН 1. ухаан сэргэлэн, үг утга оногчтой сайн, сэцэн; **цэцэн цэлмэн, цэцэн мэргэн** х о р ш.; *цэцэн ухаантай хүн;* **цэцэн үг** (олж хэлсэн оновчтой мэргэн үг; *цэцэн үг цээжинд, цэцэг навч ууланд);* 2. оноц тусгал сайтай; *цэцэн буу.*

ЦЭЦЭРЛЭГ 1. цэцэглэг; 2. ургамлын хүрээлэн; *хотын цэцэрлэг; төв цэцэрлэг; жимсний цэцэрлэг; найгасан цэцэрлэгээр хүчигдсан нутаг аа хөө, насныхаа туршид хөгжүүлэх ч нутаг аа хөө* (дуу).

ЦЭЦЭРЛЭГ II сургуулийн өмнөх насны хүүхэд багачуудыг хүмүүжүүлэх газар; *хүүхдийн цэцэрлэг; цэцэрлэгийн эрхлэгч; цэцэрлэгийн хүмүүжүүлэгч.*

ЦЭЦЭРЛЭГЖИХ цэцэрлэгтэй болох.

ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭГЧ ургамал цэцэрлэгийн мэрэгжилтэн хүн.

ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭХ цэцэрлэгжихийн үйлдүүлэх хэв.

ЦЭЦЭРЛЭГЧ цэцэрлэгийн ургамал, цэцгийг арчлан хамгаалах хүн.

ЦЭЦЭРЛЭГШИХ цэцэрлэгтэй болох, цэцэрлэг шинжтэй болох.

ЦЭЦЭРХҮҮЛЭХ цэцэрхэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭЦЭРХЭХ цэцнээ гайхуулах, мэдэмхийрэх.

ЦЭЭ (Н): эрийн цээ эр цэргийн нас; **эрийн цээнд хүрэх** (насанд хүрч цэргийн бүртгэлд орох).

ЦЭЭЖ I хүн амьтны бэлхүүс буюу харцага нуруунаас дээших хэсэг; *өргөн цээжтэй;* **цээж ихтэй** (а. хүн амьтны цээж биеэс хэтэрхий; б. үзсэн сонссоноо мартдаггүй хүн, цээжтэй ч гэдэг); **цээж сайтай** (хүний оюун ухаан хурц, юмыг мартдаггүй); **цээж тэлэх** (өвчүүний дотоод түсрэн өвдөх, цээжээр хатгуулах буюу дүүрч амьсгал бүтэх өвчин); **цээж түрэх** (оморхог зан байдал гаргах); **цээж бичиг** багшийн уншсаныг сурагчид бичих нэгэн зүйл бичгийн ажил); **цээжээр бичих** (цээж бичгийн ажил хийх); **цээжээр ярих** (бичиг, ном харалгүй санаанаасаа ярих).

ЦЭЭЖ II хонь малд тохиолдох нэгэн зүйл өвчин, малын мэнгэр.

ЦЭЭЖДҮҮ 1. малын ачаа цээждэснийг; 2. оморхог дээрэнгүй зантай.

ЦЭЭЖДҮҮЛЭХ цээждэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭЭЖДЭХ 1. малд ачих ачаа тээш хэтэрхий урагш болох, урагшдах; 2. хүний зан явдал бардам дээрэнгүй болох.

ЦЭЭЖИМЖ дотуур өмсөх хантааз, цээжмэгч ч гэдэг.

ЦЭЭЖЛҮҮЛЭХ цээжлэхийн үйлдүүлэх хэв.

ЦЭЭЖЛЭХ ном бичгийг цээждээ тогтоож хадаашруулах; *ном цээжлэх; уг цээжлэх; шүлэг цээжлэх.*

ЦЭЭЖМЭГ бөхчүүдийн барилдахад цээжинд өмсөх хувцас, зодог ч гэдэг..

ЦЭЭЖМЭГЧ эмэгтэйчүүдийн өмсөх ханцуйгүй, хүрэм мэт хувцас.

ЦЭЭЖТЭЙ 1. цээж томтой; 2. цээж сайтай, юм сайн тогтоодог.

ЦЭЭЖТЭХ малд цээж өвчин тусах.

ЦЭЭЛ 1. урсгал усны гүн гүнзгий газар; 2. газар газраас гарч, гүйхэн боловч үл ширгэх тогтмол ус; 3. аливаа юмны зайтай уужмы нь; *цээл тасалгаа;* 4. хүний санаа сэтгэл уужим тавиу, оюун ухаан хурц самбаатайгий нь; *цээл ухаан;* 5. дуулах дууны сайхан өнгө; **цээл хоолой** (дуучин эрэгтэй хүний нарийн хоолой).

ЦЭЭЛДЭХ .хэтэрхий цээл болох.

ЦЭЭЛХИЙХ цээл болох.

ЦЭЭЛШИХ цээл шинжтэй болгох.

ЦЭЭНЭ у р г а м а л хангай нутгийн ой тайгад ургадаг, үзэсгэлэнт сайхан цэцэгтэй ургамал, цэцгийн өнгө ихэнхдээ ягаан байх боловч бас цагаан байх нь бий, эмнэлэгт хэрэглэнэ, бас төл малын чацга, ханиалга зэрэгт өгөх нь бий.

ЦЭЭР I цэвэр; **цээр цэвэр** х о р ш..

ЦЭЭР II цээрлэвэл зохих зүйл; **хориг цээр** х о р ш.; **цээр тавих** (а. хөл хорьж тэмдэг тавих; б. хориглосон цээр хориогоо зогсож чөлөөтэй болгох).

ЦЭЭРГҮЙ жигшихгүй, эрээгүй, хориогүй.

ЦЭЭРЛҮҮЛЭХ 1. цээрлэхийн үйлдүүлэх хэв; 2. ял шийтгэл ногдуулах.

ЦЭЭРЛЭЛ 1. цээрлэх үйлийн нэр, гажуу буруу буюу муу муухайг хориглон сургасны нь; *цээрлэл болгох;* 2. дагаж гүйцэтгэхэд болохгүй юмны учир чанарыг элдэв аргаар таниулах мэдрүүлэхий нь; 3. ял; **ял цээрлэл** х о р ш.; **цээрлэл үзүүлэх** (ял буруушаал ногдуулан залхаах.

ЦЭЭРЛЭЛГЭЭ 1. цээрлэх зүйл; 2. хөл хорьж үүд хаалганы гадаа тавьсан тэмдгийн зүйл.

ЦЭЭРЛЭЛТ 1. гажуу мууг хориглож сайнд сургасан үг бичиг; 2. *аливаа цээрлэсний нь.*

ЦЭЭРЛЭМТГИЙ цээрч.

ЦЭЭРЛЭХ 1. цээр бүхий зүйлийг үл хийх; *архи цээрлэх; шар өвчнөөр өвдсөн хүн мах идэхийг цээрлэвэл зохино;* **хөл цээрлэх** (хөл хорих); **нэр цээрлэх** (а. эцэг эх, ах нар, уул ус зэргийг жинхэнэ нэрээр үл хэлэх; б. аюул хөнөөлтэй юм, үзэгдлийн нэрийг нэрлэхгүй, өөр үгээр хэлэх; *үхрийн мялзанг цагаан өвгөн гэж цээрлэдэг; чоныг цээрлэн хээрийн нохой гэнэ);* 2. сэжиглэх; **цээрлэх сэжиглэх**

ЦЭЭРТ цээр бий.

ЦЭЭРТЭЙ цээр бүхий; *цээртэй газар; цээртэй айл; хөл цээртэй гэр.*

ЦЭЭРЧ цээрлэмтгий хүн; **цээрч цэвэрч** х о р ш..

Ч

Ч I Ч үсэг, Ч авиа.

Ч II дутагдах сул үг; *тэр ч; энэ ч; бас ч; харин ч; дуртай ч тэр, дургүй ч тэр, тушааж байна чамд.*

ЧАА хонь ямааг зандахад хэрэглэх аялга; *хаая чаа! хүүе чаа!*

ЧААВАС тэсч ядан халаглах, гаслахад хэрэглэх аялга үг; *чаавас, данч ийм хэрэг болох гэж дээ! чаавас, яав дан ч ингэх гэж байх уу!*

ЧАВГА у р г а м а л модонд ургах жимсний нэр, гүйлснээс бяцхан бөгөөд уртхан, цөмөө хоёр этгээд шуумгай, амт амтайхан, өнгө улаан, модны бие салаанд сондуу бий, цэцэг шаравтархан ногоовор; **хар чавга** (хар өнгөтэй нэг зүйл чавга); **улаан чавга** (улаан өнгөтэй нэг зүйл чавга): **нанжин чавга** (Нанжин буюу өмнөд нийслэлийн хавь газар ургах нэг зүйл чавга).

ЧАВГАНЦ 1. шашны сахил авч лам болсон эмэгтэй; **чавганц болох** (чавганц сахил авах); **чавганц яриа** (эх зах, үүсгэл төгсгөлгүй яриа); 2. ш и л ж с э н настай эмэгтэй хүн.

ЧАВДАГ 1. маш ховор; *юм чавдаг жил; идэх юм чавдаг айл;* 2. чавхуун, харамч **чавдаг харамч, чавдаг хэвцгий** х о р ш.; *чавдаг хүн;* 3. нүх сүвээр шингэн юмны дусал дуслаар тасалдан гоожихы нь.

ЧАВДАГДАХ хэтэрхий чавдаг болох.

ЧАВДАГЛАХ 1. харамлах, харуусах; *чи чавдаглах хэрэг алга шүү;* 2. шингэн юм чавдаг байдлаар гарах.

ЧАВДАГРАХ чавдаг болох, хомсдох, ховордох; *юм чавдаграх; шээс чавдаграх.*

ЧАВДАГРУУЛАХ чавдаграхын үйлдүүлэх хэв.

ЧАВДАГСАХ улам чавдаг болох.

ЧАВДАГТАХ чавдаг байдал гаргах.

ЧАВДАГШИХ чавдаг болох, чавдаг шинжтэй болох, ховорших.

ЧАВДГАРХАХ чавдаг зан гаргах, чавдаг болох.

ЧАВРИ Буддын шашны ёсны гэлэн санваарын тэмдэг, бүснээс дүүжлэн урдаа зүүж явдаг дөрвөлжин зүйл.

ЧАВХ I харвах зэвсэг, байдал нум мэт болоод жижиг; *чавхаар харвах.*

ЧАВХ II юмыг эсгэх тоймлох зэрэгт ором зургийг гаргахад хэрэглэх утас; *эсгүүрчний чавх; мужааны чавх.*

ЧАВХ III булга хэрэм зэрэг амьтныг агнахад хэрэглэх нэгэн зүйл урхи; *урхин чавх; чавхан урхи.*

ЧАВХААХАЙ чавх.

ЧАВХАЙ бага хүүхдийн булиа тарган, өргөх тэврэхэд хүнд жинтэйгий нь, чамбай ч гэдэг.

ЧАВХАЙРАХ чавхай болох.

ЧАВХДАС хөгжмийн утас; *чавхдаст хөгжим; хуурын чавхдас; ятгын чавхдас.*

ЧАВДАСЛАХ хөгжимд чавхдас хийх.

ЧАВХДАСТАЙ чавхдас бүхий юм; *хоёр чавхдастай; арван хоёр чавхдастай ятга.*

ЧАВХДАХ 1. урхин чавхны тийрэх; *булга чавхдаж агнах;* 2. чавхаар тийрүүлж харвах; *зурам чавхдаж харвах;* 3. юманд чавх тавьж ором гаргах; *утсаар чавхдаж ором шугам гаргах;* 4. няслах ба шавдах; *бугуй дээр нь хоёр хуруугаар чавхдах;* 5. ш и л ж с э н хүн амьтны асар хурдан гүйх давхих; *хүүхэд чавхдан гүйх.*

ЧАВХУУН 1. хөшүүрхсэн зан байдал; *чавхуун зантай амьтан;* 2. эд юманд нарийн харамч.

ЧАВХУУРАХ чавхуун байдал гаргах.

ЧАВХУУРУУЛАХ чавхуурахын үйлдүүлэх хэв.

ЧАВХУУРХАХ чавхууран хэвцэглэх, чавхуун зан байдал гаргах, хэгжүүрхэх.

ЧАВЧИРГА х у у ч и р с а н Манж Чин улсын эрүү шүүлтийн нэг зүйл бөгөөд хүнийг жанчих урт банз; **чавчирга авах** (есөн эрүүгийн нэг зүйл, урт банзаар 60—100 тоолон жанчих).

ЧАВЧИРГАДАХ чавчиргаар жанчих, дэлдэх.

ЧАВЧИРГАДУУЛАХ чавчиргадахын үйлдүүлэх хэв.

ЧАВЧИРГАЛАХ чавчиргадах.

ЧАГНААЛ сонсох дохио; *машины чагнаал.*

ЧАГНААЛДАХ чагнаал дуугаргаж дохио өгөх.

ЧАГНАЛ чагнах үйлийн нэр.

ЧАГНАХ 1. сонсох; *өвгөн аавынхаа үгийг чагнаж суу; алсаас гарах машины дууг чих тавин чагнав;* 2. хүмүүсийн үг уриа зэргийг нууцгай чих тавин сонсох; *хүмүүсийн ярьж байгааг хаалганы завсраар чагнаж байв.*

ЧАГНУУЛ юм чагнах хүн.

ЧАГНУУЛАХ 1. чагнахын үйлдүүлэх хэв; 2. чагнагдах.

ЧАГНУУЛЧ чагнуул.

ЧАГНУУР чагнах хэрэгсэл; *эмчийн чагнуур; утасны чагнуур.*

ЧАГТ (АН) 1. юмыг товчлох, торгоход зориулсан шилбэ бүч, шижим оосрын үзүүрт хийсэн хөндлөн юм; *тугалын чагт; зэлийн чагт; чагтан товч; ясан чагт; модон чагт;* 2. ш и л ж сэн саад садаа; *чагт тавих; чагт хийх.*

ЧАГТАЙХ хүн амьтны гэдэс гүзээ дүүрч тэлэгдэх; *гэдэс чагтайх.*

ЧАГТГА 1. монгол гэрийн тоононы голоос уях оосор; **чагтга авах** (тоононы чагтгаас хүнд юм уях зэргээр доош даруулах); 2. ш и л ж сэ н саад: **саад чагтга х о р ш.**; *чагтга тавих; чагтга хийх; чагтга болох.*

ЧАГТГАЛАХ 1. тоононы чагтганаас хүнд юм уяж чагтга авах; 2. ш и л ж с э н саад тоторгор хийх; *явахын даваанд дээр чагтгалах.*

ЧАГТГАЛУУЛАХ чагтгалахын үйлдүүлэх хэв.

ЧАГТЛАГДАХ чагтлахын үйлдэгдэх хэв.

ЧАГТЛАХ 1. юмыг чагтаар торгох; 2. ш и л ж с э н хүний ажил үйлд саад садаа хийх.

ЧАГТЛУУЛАХ 1. чагтлахын үйлдүүлэх хэв; 2. чагтлагдах.

ЧАГТУУН нум богинодож татахад авсаар дийлдэхгүй хатуугий нь; **чагтуун хатуу** х о р ш.; *чагтуун нум.*

ЧАГЧИГ цагчиг.

ЧАДАГДАХ чадахын үйлдэгдэх хэв.

ЧАДАЛ 1. тамир, тэнхээ, бяр хүч; **хүч чадал, чадал тамир, бяр чадал** х о р ш.; **чадал суух, чадал нэмэх** (чадал улам нэмэгдэх); **чадал орох** (а. чадалтай болох, б. чадал шаардагдах); **чадал гаргах** (чадал нь илрэн мэдэгдэх, мэрийн зүтгэх); **чадал сайтай, чадал ихтэй** (а. тэнхээ хүч ихтэй; б. үйл ажлыг бүтээхдээ чадамгай: в. хөрөнгө амьдрал элбэг хүрэлцээтэй); **чадал муутай, чадал багатай** (а. тамир тэнхээ дорой; б. хөрөнгө чинээ багатай; в. мэдлэг чадвар муутай); **чадлаа үзэлцэх** (а. тамир тэнхээгээ үзэх; б. мэдлэг чадвараа үзэх; в. хөрөнгө чинээгээ үзэх); **чадал мэдэх** (а. тамир тэнхээ мэдэх: б. мэдлэг чадвар мэдэх; в. хөрөнгө чинээ мэхдэх); 2. эрдэм мэдлэг, ид чадвар; **мэдэл чадал, эрдэм чадал, ид чадал** х о р ш.; *энэ шалгалтаар тэр залуу харин нэг чадал зааж байгаад онц гарлаа даа;* 3. хөрөнгө чинээ; **чадал чинээ, хөрөнгө чадал** х о р ш.; **мөнгөний худалдан авах чадал** (тухайн мөнгөний нэгжээр худалдан авч болох таваарын хэмжээ).

ЧАДАЛГҮЙ 1. тэнхээ дорой; 2. мэдлэг боловсрол сайнгүй; 3. байдал үхээнц муу; 4. хөрөнгө амьдрал ядуу.

ЧАДАЛЖИХ чадал сайтай болох, чадал суух.

ЧАДАЛЖУУЛАХ чадалжихын үйлдүүлэх хэв.

ЧАДАЛТАЙ чадал бүхий, бяр тэнхээ ихтэй, мэдлэг чадвар сайтай, хөрөнгө амьдарлага сайтай; *ажиллах чадалтай; амьдрах чадалтай; чадалтай бөх.*

ЧАДАЛТАН чадал бүхий этгээд.

ЧАДАМГАЙ үйл ажилд мэдлэг чадвар сайтай, дадамгай, сурамгай; *чадамгай жүжигчин; чадамгай мужаан; чадамгай оёдолчин; чадамгай жолооч; чадамгай тамирчин; моринд чадамгай.*

ЧАДАМГАЙДАХ чадамгай нь хэтрэх.

ЧАДАМГАЙРХАХ чадамгайдаа эрдэж хэтрэн явах.

ЧАДАМГАЙРХУУЛАХ чадамгайрхахын үйлдүүлэх хэв.

ЧАДАН: чадан ядан арай чамай; *чадан ядан орчуулах; чадан ядан үйлдэх; чадан ядан гүйх.*

ЧАДАХ 1. үйл явдлыг гүйцэтгэх чадвартай; болох; *хийж чадах ажил; морь унаж чадах; бичиж чадах; дуулж чадах; ярьж чадах;* **чадах чинээгээрээ, чадах ядахаараа,** үйл ажилд санаа хүчнийг шавхан гаргахы нь); 2. бусдыг хясан хяхах; *чи намайг хэрэгцээтэй цагт сайхан чадлаа даа.*

ЧАДВАР чадал; **мэрэгжил чадвар, чадал чадвар** х о р ш.; *чадвар бага; чадвар муу; чадвар мөхөс; чадвар сайн; чадвар их; ажиллах чадвар; амьдрах чадвар; эрдэм чадвар; самбаа чадвар; дадлага чадвар; чадвараа дээшлүүлэх; чадвар суух; чадвар нэмэгдэх.*

ЧАДВАРГҮЙ чадвар чадал муу, бага, дорой, мөхөс.

ЧАДВАРЖИХ чадвартай болох, чадвар суух.

ЧАДВАРЖУУЛАХ чадваржихын үйлдүүлэх хэв.

ЧАДВАРЛАГ чадамгай, чадвартай.

ЧАДВАРЛАХ чадамгайгаар бүтээх, чадвараа гаргах.

ЧАДВАРТАЙ чадвар бүхий, чадалтай; *хөдөлмөрийн чадвартай; мэдлэг чадвар сайтай; чадвартай чинээлэг айл; чадвартай хөгжимчин.*

ЧАДЛАРХАГ чадал чадвар сайтай.

ЧАДЛАРХАХ чадалтайдаа эрдэх.

ЧАДЛАРХУУ чадлархаг.

ЧАДМАГ 1. чадамгай, дадамгай, сурамгай; *чадмаг хүн; чадмаг мужаан;* 2. хөрөнгө амьдрал сайтай; *чадмаг айл.*

ЧАДМАГДАХ хэтэрхий чадмаг болох.

ЧАДУУХ тарианы түрүү ургаж цоморлигтох; *тариа чадуух.*

ЧАДХАЙХ хүний уур хилэн хөдөлж, амьсгал бүдэгдэн нүүр нь минчрэн улайх; *нүүр царай нь чадхайсан сүрхий амьтан.*

ЧАДХАГАР 1. хүн амьтны бие нарийлаг чангалгий нь; *чадхагар нарийн биетэй;* 2. хувцасны давчуу явцуугий нь; *чадхагар дээл.*

ЧАЛБАН нүдний тар улангир болсны нь; **чалбан цагаан** (морины өнгө цагаан болоод, нүд, хамар, уруулын орчин улаавтар ягаан),

ЧАЛЧАА дэмий үг ярих дуртай, олон үгтэй; *чалчаа хүн; чалчаа үг.*

ЧАЛЧААДАХ хэтэрхий чалчаа болох, хүний насжиж хэлэлцсэн үгээ мартаж байн байн хэлэлцэх болох.

ЧАЛЧААРАХ чалчаа болох, дэмий ярих.

ЧАЛЧИХ хэрэггүй дэмий үг, болгоомжгүй ярих; *дэмий чалчиж цаг нөхцөөх хэрэггүй.*

ЧАЛЧРАА хэл нь чулчиг сул; *чалчраа хэлтэй.*

ЧАЛЧРААТАХ чалчраа байдал гаргах.

ЧАЛЧРАХ ярихдаа хэл нь чулчрах; *хэл чалчрах; чалчран хэлэх.*

ЧАЛЧРУУЛАХ чалчрахын үйлдүүлэх хэв.

ЧАМ хоёрдугаар биеийн төлөөний ганц тоог заасан үг бөгөөд нэрлэхийн тийн ялгалаас бусад тийн ялгалд ялгаллагдах үндэс; *чам шиг сэргэлэн хүнийг би үзээгүй; чамаас би үзгий чинь авах гэсэн юм; би чамтай явна.*

ЧАМАЙ зүдэн ядан, дөнгөн данган; **арай чамай, чуу чамай** х о р ш.; *арай чамай гүйцэв; чуу чамай амжив.*

ЧАМАЛХАЙ авах идэхийн зэрэгт ханалгүй гоморхох зан, чамламхай ч гэдэг.

ЧАМАР тосонд багсарсан, арвайн гурил.

ЧАМАРЛАХ чамар болгох, чамар хийх; *гурил чамарлах.*

ЧАМАРЛУУЛАХ чамарлахын үйлдүүлэх хэв; *гурил чамарлуулах.*

ЧАМАРХАЙ магнайн хоёр хажуу.

ЧАМАРХАХ гоморхох, чамлах байдал гаргах, чамлах; **гоморхох чамархах; чамлах чамархах** х о р ш..

ЧАМЛАМТГАЙ чамламхай 

ЧАМЛАМХАЙ чамалхай, чамлах зантай, чамламтгай; *чамламхай хүүхэд.* 

ЧАМЛАХ хүссэн ээрсэн зүйл санасанд хүрэхгүй гоморхох; *хүүхэд хусмаа чамлах; хүн эрдмээ чамлах; эцэг эх нь хөвгүүний сурлагыг чамлах; чамлахаар чанга атга* х у у ч.

ЧАМЛУУЛАХ чамлахын үйлдүүлэх хэв.

ЧАМХУУН чавхуун, хэгжүүн, **чавхуун чамхуун** х о р ш.. 

ЧАНАГШ цаана, цааш.

ЧАНАГШДАХ цаанадах, цаашдах. 

ЧАНАГШДУУЛАХ чанагшдахын үйлдүүлэх хэв. 

ЧАНАГШЛАХ цаашлах, цааш болох. 

ЧАНАГШЛУУЛАХ чанагшлахын үйлдүүлэх хэв.

ЧАНАЛГА 1. чанах үйлийн нэр; *чаналга даах гурил;* 2. чанадаг юм; *чаналга тос.* 

ЧАНАМАЛ чанаж боловсруулсан юм; *чанамал тутрага;* **чанамал жимс** (жимс, жимсгэнийг чихэртэй найруулан чанасан нэг зүйл идээ). 

ЧАНАР аливаа юмны бодит шинж тэмдэг, яс, нэг юмыг нөгөөгөөс ялгах онцлог; **яс чанар, шинж чанар** х о р ш.; **чанар сайтай, сайн чанартай** (а. юмны яс, бод, мөн шинжийн хувь илүү давуутий нь; б. хүний ханш ханилгаа, зан байдлын хувь сайны нь); **чанар муутай, муу чанартай** (а. юмны яс бод, мөн чанарын хувь сайн биший нь; б. хүний ханш ханилгаа, зан байдлын хувь сайнгүйгий нь); **тоо чанар** (аливаа юмны тоо болон үйлдсэн яс); **байдал чанар** (юмны хэлбэр хийгээд агуулга); **үнэн чанар** (юмны үнэн, мөн); **бодит чанар** (юмны жинхэнэ яс); **мөн чанар** (юмны үндэс, агуулга); **чухам чанар** (үндсэн агуулга); **чанартай хоол** (тэжээлийн зүйл ихтэй сайн хоол); **чанартай эм** (өвчин анагаах чадалтай эм); **халуун чанартай** (халуувтар байдалтай); **хүйтэн чанартай** (хүйтэвтэр байдалтай); **чанартай үг** (жинтэй үг); **чанартай ажил** (сайн ажил); **хуурамч чанар** (үнэн биш чанар); **чанарын хувьсал** (алив юмны аажим аажмаар тооны хувьсал болсоор үндсэн өөрчлөлт орох хувьсал). 

ЧАНАРГҮЙ чанар муутай. 

ЧАНАРЖИХ чанар байдал улам сайн болон сайжрах, чанартай болох. 

ЧАНАРЖУУЛАХ чанаржихын үйлдүүлэх хэв, чанартай болгох.

ЧАНАРТ чанартай.

ЧАНАРТАЙ чанар бүхий; *чанартай таваар; чанартай бүтээгдэхүүн.* 

ЧАНАТ янат гэдэгтэй эсэргүүцэлдсэн үг, цаад ч гэнэ; *мөрний чанат; байшин харагдана; байшингийн чанат гэр бий; хоосон огторгуйн чанат хязгааргүй.*

ЧАНАХ аливаа юмыг буцалгаж боловсруулах; *цай чанах; хоол чанах; жимс чанах; чанасан мах; чанасан будаа.*

ЧАНГА сул гэдгийн эсрэг утга; 1. дуу чимээний өндөр их; *чанга дуутай хүн; чанга ярих; чанга дуугарах;* 2. хүчтэй ширүүн; *чанга цохих; тасхийтэл чанга алгадав; чанга бариарай; чанга түлхэх; чанга үлээх* 3. хууль зарчим, зан сэтгэл зэргийн нарийн чанд хатууг; **хатуу чанга** х о р ш.; *чанга шийтгэл; хууль дүрэм чанга; чанга багш; чанга тушаах; чанга зориг;* 4. эд юмны нягт чийрэг; *чанга нэхээстэй бөс; эрч нь чанга байв;* 5. уяа хүлээсний бат бэх; *чанга баглаатай ачаа; чанга татаад уяарай;* 6. юмны амт хахуун хүчтэй; *давс нь чанга байна;* ☆ **чанга эм** (чадал хүч ихтэй эм); **чанга эгшиг** (хэлний ар этгээдээр өгүүлэгдэх эгшиг). 

ЧАНГААЛГАХ 1. чангаахын үйлдүүлэх хэв; 2. чангаагдах. 

ЧАНГААМАЛ хуурч боловсруулсан нэгэн зүйл будаа; *чангаамал будаа .*

ЧАНГААХ 1. юм хумнаас барьж **татах, үгтээх: татах чангаах, үгтээх чангаах** х о р ш.; *гараас нь чангаах; хормойгоос нь чангаах; бүслүүрийн үзүүрээс чангаах;* 2. үйл ажлыг хойшлуулах, удаашруулах, **татгалзаж** хойргошиx, садаа болох; *давшилт хөгжилтөөс хойш сууж чангаавал туйлын буруу билээ.*

ЧАНГААЦАЛДАХ чангаахын үйлдэлцэх хэв. 

ЧАНГАД хатуу, чанд, хүнд; *чангаас чангад цээрлүүлэн шийтгэвэл зохино.*

ЧАНГАДАХ чанга нь нэндэх; *дуу нь чангадах; гар нь чангадах; шийтгэл чангадах; хүжир нь чангадах; эрч нь чангадах; олом нь чангадах.*

ЧАНГАДУУЛАХ чангадахын үйлдүүлэх хэв. 

ЧАНГАЛАГ нилээд чанга, чангахан.

ЧАНГАЛАХ чанга болгох, чангатгах.

ЧАНГАЛУУЛАХ 1. чангалахын үйлдүүлэх хэв; 2. чангалагдах.

ЧАНГАРАХ чанга хатуу болох; *хүний зан чангарах; бие чийрэгжиж чангарах; ойрноос хүйтэн чангарч байна; уяа хүлээс чангарах; өвчин чангарах; эсгий чангарах.*

ЧАНГАРУУЛАГЧ чангаруулах этгээд.

ЧАНГАРУУЛАХ чангарахын үйлдүүлэх хэв.

ЧАНГАСАХ чангатах; *бүрээний дуу улам чангассаар байв; хүйтний хүч чангасах; хууль чангасах.*

ЧАНГАСГАХ чангасахад хүргүүлэх, чангатгах.

ЧАНГАТАХ улам чанга болох, чангарах.

ЧАНГАТГАГЧ чанга болгодог юм.

ЧАНГАТГАХ чангатахын үйлдүүлэх хэв, чангаруулах.

ЧАНГАХАН арай чанга, нилээд чанга.

ЧАНГИЛЗУУР цантай адилхан болоод тархи жижигхэн нэгэн зүйл хөгжмийн зэвсэг.

ЧАНД 1. маш бат, чанга, хатуу; **чанд хатуу** х о р ш.; *чанд хөлдөх;* 2. нарийн хатуу; **нарийн чанд** х о р ш.; *чанд сахих; чанд баримтлах.*

ЧАНДАА х у у ч и р с а н гааль оноох барааны цэс.

ЧАНДАГА а м ь т а н цагаан зүсэмтэй нэг зүйл туулай.

ЧАНДАР I шувууны биеийн үс; **өд чандар** х о р ш.. ɔ

ЧАНДАР II чандруу.

ЧАНДАР III хүндэтгэвэл зохих хүний хүүр; **хүүр чандар** х о р ш..

ЧАНДЛАЛЦАХ 1. чандлахын үйлдэлцэх хэв; 2. барилдахад харилцан хүч тэнцэлцэх.

ЧАНДЛАХ чанд болгох, нарийн болгох, хатуу болгох.

ЧАНДЛУУЛАХ 1. чандлахын үйлдүүлэх хэв; 2. чаднлагдах.

ЧАНДМАНЬ үлгэрт гардаг, юу хүссэнийг хангах чухаг зүйл гэнэ; *мал бол манай хүслийг хангагч чандмань эрдэнэ мөн* х у у ч.

ЧАНДРУУ I галаас гарах үнс мэт жижиг зүйл; *үнсэн чандруу болгох.*

ЧАНДРУУ II цэцэг өвчин; **цэцэг чандруу** х о р ш..

ЧАНДРУУТАХ 1. чандруутай болох; 2. цэцэг өвчин хүрэх.

ЧАНДРУУШИХ чандруу шинжтэй болох.

ЧАНС: чанс жимс у р г а м а л туурын адил хэлбэртэй, исгэлэн амттай, өнгө шар нэгэн зүйл жимс, давсанд дарж иднэ.

ЧАНСАА яс, чанар; **чанар чансаа** х о р ш..

ЧАНТУУ узбек; **чантуу малгай** (нэгэн зүйл оройвч малгай); **чантуу эсгий** (узбекүүдийн гараар хийдэг нэг зүйл нарийн эсгий).

ЧАНУУЛАХ чанахын үйлдүүлэх хэв.

ЧАНХ 1. эгц, цэх, яг; *чанх зүүн тийш; чанх урагшаа хар; чанх урүү* 2. эрс тэс, тэрс; **чанх өөр** (огт адилгүй өөр): **чанх буруу** (маш зүйгүй); **чанх зөруу** (маш гажуу буруу). ɔ

ЧАНХИЛЗУУР танхилган, танхилзуур; **чанхилзуур таяг** (дулдуй).

ЧАРАЙ: арай чарай дөнгөн данган, чуу чамай чадан ядан; *арай чарай өргөж байв; арай чарай дийлэв.*

ЧАРАЙХ мэрийх чармайх, улайх; *ажилд чарайж ажиллах; уйлахгүй гэж чарайх; ноцолдох гэж чарайх.*

ЧАРАМ огт нүцгэн; *чарам бие;* чармай ч гэдэг.

ЧАРАМХАН нимгэн хувцас; *чарамхан хувцас өмсөх.*

ЧАРАМХИЙХ хөдлөх чадвартай нь; *ажилд чарамхийх нь гарах хэрэгтэй.*

ЧАРГА I битүү цасан дээгүүр малын хөлөөр гарсан ором зам; *малын чарга гарчээ; чарга дагаж явах.*

ЧАРГА II цас мөсөн дээгүүр явах гулгуур бүхий хэрэгсэл; *чаргаар явах; чаргаар гулгах.*

ЧАРГАГ явцуу давчуу; *чаргаг углуурга.*

ЧАРГАГДАХ хэтэрхий чаргаг болох; *хоолой чаргагдах; углуурга нь чаргагдах.*

ЧАРГАЙ модны шудрага өндөр болоод ягц ургасны нь.

ЧАРГАЛАХ чаргаар чирэх, чаргаар явах.

ЧАРГАЛУУЛАХ чаргалахын үйлдүүлэх хэв.

ЧАРГУУ 1. юмны чаргаг хатуу; 2. хүний донгио бүдүүлэг.

ЧАРГУУДАХ хэтэрхий чаргуу болох.

ЧАРГУУДУУЛАХ чаргуудахын үйлдүүлэх хэв.

ЧАРГУУЛАХ чиргүүлэх, чаргуулдах, зүүцэлдэх.

ЧАРГУУЛДАХ чиргүүлдэх, зүүцэлдэх; *надаас битгий чаргуулдаад байгаарай.*

ЧАРГУУСАХ улам чаргуу болох.

ЧАРГУУСГАХ чаргуусахад хүргүүлэх

ЧАРГУУТАХ чаргуусах, улам чаргуу болох.

ЧАРГУУТГАХ чаргуутахад хүргүүлэх.

ЧАРДАЙЛГАХ чардайхын үйлдүүлэх хэв.

ЧАРДАЙХ чардгар болох.

ЧАРДАЛЗАХ чардгар юмны байн байн **хөдлөх.**

ЧАРДГАНАХ чардгар юмны үргэлжлэн хөдлөх.

ЧАРДГАР нүцгэн, туранхай; *чардгар хүүхэд.*

ЧАРЛАА орилоо, бархираа, чарламтгай; *чарлаа хүүхэд.*

ЧАРЛААХ орилуулах, чирлуулах

ЧАРЛАМТГАЙ чарламхай.

ЧАРЛАМХАЙ маш их чаралдаг, чарламтгай.

ЧАРЛАХ бархирах, орилох; **орилох чарлах, бархирах чарлах** х о р ш.; *хүүхэд чарлах.*

ЧАРЛУУЛАХ чарлахын үйлдүүлэх хэв.

ЧАРМАА чарам, нүцгэн; *чармаа нүцгэн.*

ЧАРМАЙЛГАХ чармайхад хүргүүлэх.

ЧАРМАЙЛТ чармайх үйлийн нэр; *чармайлт гаргах; чармайлт тавих.*

ЧАРМАЙХ мэрийх, зүтгэх, шамдал гаргах; *чармайж хийх.*

ЧАРМАХ 1. олон юманд ухаан самуурч төөрөгдөн дэмий мунгинах; 2. чармайх, мэрийх, чарайх.

ЧАС I: **час улаан** ув улаан, цусан улаан.

ЧАС II 1. ногоо тарих газар; **цэцгийн час** (цэцэг тарихын тулд овоолсон шороон зурвас); 2. тутрага тарих тариалангийн талбай.

ЧАС III: **час час хийх** 1. бие махбод сочмог чим чим хийх; *хурууны өндөг час час хийв;* 2. дуу чимээний чанга огцом огцом сонсдох; *хүүхэд час час хийтэл бархирав.*

ЧАТХАЙХ 1. чатхагар болох, хилэгнэж нүүр улайх; 2. бие хавдаж улайх.

ЧАТХАГАР давч, явцуу, бариу; *чатхагар цамц.*

ЧАХРАХ юмны хавиран чихэрч дуугарах; *тэрэг чахрах; цас чахрах.*

ЧАХРУУЛАХ чахрахын үйлдүүлэх хэв.

ЧАХРУУН чахарсан дуу; *чахруун дуу.*

ЧАЦ хүн амьтны мөч; **чац мөч** х о р ш.: *чац урт; чац богино.*

ЧАЦАВ: чацав чацав хийх, чацав татав хийх амьтны биеийн энд тэнд татав татав хөдлөх.

ЧАЦАВГАНАХ хүн амьтны биеийн чацав татав хийх; *хацар чацавганах.*

ЧАЦАВХИЙХ ямар нэгэн юмнаас цочин бие догдолсхийх, татганан хөдлөх; *нойрон дунд цочин чацавхийх; өргөсөнд хатгагдаж чацавхийх; галд хайрагдаж чацавхийх.*

ЧАЦАЛЗАХ чацганах, чацвалзах.

ЧАЦАРГАНА у р г а м а л өндөр бөгөөд өргөстэй, сөөг модонд ургадаг, исгэлэн амттай шар жимсгэнэ, идэж болно.

ЧАЦАРХАГ чац ихтэй.

ЧАЦАРХАЙ мал гөрөөсний, өөхтэй нарийн гэдэс.

ЧАЦАРХАЙЛАХ төл малын төрсний даруйд шингэнээр баах,

ЧАЦАРХУУ чацархаг, чац томтой.

ЧАЦАСХИЙХ чацавхийх.

ЧАЦВАЛЗАХ 1. амьтны бие махбод татганан хөдлөх, татвалзах; 2. хүний долгин, тогтуурь сууригүй, хөдөлгөөнтэй болох.

ЧАЦГА хүн амьтны маш шингэн баас; **чацга алдах** (чацга өвчин хүрэх ба шингэнээр баах).

ЧАЦГАНАХ чацавганах.

ЧАЦУУ 1. адил хэмжээтэй юм; *юмны урт богиныh хэмжээ чацуу;* 2. хүн амьтны нас адил; *чи бид хоёр чинь чацуу билүү;* 3. зэргэлдээ хамт болохы нь; *очихын чацуу; ирэхийн чацуу; унтахын чацуу.*

ЧАЦУУДАХ хэтэрхий чацуу болох.

ЧАЦУУЛАХ юмны урт охор, өргөн нарийн зэргийг зэрэгцүүлэн адилтгаж үзэх.

ЧАЦУУЛУУЛАХ чацуулахын үйлдүүлэх хэв.

ЧАЦУУРАХ чацуу болох.

ЧАЦУУРУУЛАХ чацуурахын үйлдүүлэх хэв.

ЧАЦУУРХАХ чацуу гэж найзархах, хөөрөлхөх.

ЧАЦУУСАХ улам чацуу болох.

ЧАЦУУСГАХ чацуусахад хүргүүлэх.

ЧЕК банкнаас мөнгө авах мэдүүлэг.

ЧИ I хоёрдугаар биеийн ганц тоог заасан төлөөний үг; *чи яв! чи ир! чи мэднэ; чи харицуна;* **чи би дээ хүрэлцэх, чи би дээ хүрэх** (сайн муугаа дуудалцаж хэрэлдэх).

ЧИ II нэгэн зүйл бишгүүр хөгжим; *чи хөгжмөөр хөгжимдөх.*

ЧИВ I: **чив чимээгүй** огт чимээ аниргүй; *чив чимээгүй болох.*

ЧИВ II эр амьтны бэлгийн эрхтэн; *бугын чив; нохойн чив.*

ЧИВ III: **чив чив хийх** шингэн юмны дусал дуслаар унах чимээ гарах; *ус чив чив дусах.*

ЧИВ IV: **чив чиг** шув шулуун, яг тохирсон, цэх; *чив чиг яваад хүрэв; чив чигээрээ яваад л хүрнэ.*

ЧИВҮҮЛЭХ чивэхийн үйлдүүлэх хэв.

ЧИВҮҮР өөш зэрэг зүйлд уях, усанд живэх юм.

ЧИВХ оньс, түгжээ, дэгээ, шор.

ЧИВХДҮҮЛЭХ чивхдэхийн үйлдүүлэх хэв.

ЧИВХДЭХ оньслох, түгжих, шорлох.

ЧИВХИЙХ усны дусал зэргийн унах чимээ гарах.

ЧИВЧИН Баргын нэгэн аймгийн нэр; *Чивчин барга.*

ЧИВЧҮҮР газар шороо малтахад хэрэглэх шоо оольд адилхан, төмөр зэвсэг.

ЧИВЭГЧ дуулганд хадсан жажуурын халхавч.

ЧИВЭГЧИТ чивэгч бүхий; **чивэгчит малгай** (чихийг даруулан өмсөх чивэвч бүхий малгай).

ЧИВЭЛ нүгэл; **нүгэл чивэл** х о р ш..

ЧИВЭЛТ нүгэлт, чивэлтэй.

ЧИВЭХ усанд юм далд орж одох, живэх гэдэг.

ЧИГ I 1. шулуун, эгц, зүг; **зүг чиг, чиг шулуун** х о р ш.; *чиг замаар явахад дөт; чиг харалдаа байгаа айл; чиг урагшаа; чиг баруун тийшээ;* **хэвтээ чиг** (зүүнээс баруун тийш хандсан чиг); **босоо чиг** (дороос дээш хандсан чиг); **чиг чигтээ** (зүг зүгтээ): **чигтээ явах** (а. мөрөөрөө шулуун явах; б. бүрмөсөн явах); **чигээ хөөх, чигээ харах** (хувь мөрөө хөөх); **алсын чиг** (алсын зорилт; *манай алсын чиг);* **чиг журам** (заншил, журам); **чиг үүд** (хулсны ширхэг буюу зэгс дэрсний ишээр хийсэн үүд цонхны хаалт хөшиг); 2. учир; *энэ ажлын чигийг олов; учир чиг нь тийм болж байна.*

ЧИГ II хүн амьтан, юмны хугарсан, бэртсэн, гэмтсэн газарт түшиг болгон хавчиж боох нарийн мод; *гарт нь чиг барих; үүрганы залгаасанд чиг барьж бэхлэх.*

ЧИГ III дутагдах сул үг, Ч; *тэр чиг яах вэ; энэ чиг болно; мөнгө чиг алга.*

ЧИГГҮЙ 1. алсын хараагүй, бодлогогүй; 2. зүг, мөр, замгүй; 3. эрс шийдвэр байхгүй; 4. сураг ажиггүй.

ЧИГЖ шигүү, няг, ягц.

ЧИГЖИХ 1. чигж болгох, чихэж чигжрүүлэх; *шороо чигжих;* 2. чигжээ хийх; *модоор чигжих.*

ЧИГЖРҮҮЛЭХ чигжрэхийн үйлдүүлэх хэв.

ЧИГЖРЭХ чигж болох, чигжүү болох.

ЧИГЖҮҮ чигж, шигүү, ягц, няг; *чигжүү бичих.*

ЧИГЖҮҮДЭХ хэтэрхий чигжүү болох.

ЧИГЖҮҮЛЭХ чигжихийн үйлдүүлэх хэв.

ЧИГЖҮҮХЭН арай чигжүү, нилээд чигжүү.

ЧИГЖЭЭ 1. чигжээс; 2. хэвлэлийн өрөлтөд үг болон үсгийн хоорондхийх цулгуй чигжээс.

ЧИГЖЭЭС чигжих юм, чигжээ.

ЧИГЖЭЭСЛҮҮЛЭХ чигжээслэхийн үйлдүүлэх хэв.

ЧИГЖЭЭСЛЭХ чигжээс хийх, *чигжээтэй болгох чигжих.*

ЧИГЛҮҮЛЭГЧ чиглүүлэх үйл гүйцэтгэгч; *удирдан чиглүүлэгч.*

ЧИГЛҮҮЛЭХ чиглэхийн үйлдүүлэх хэв, чигий нь зааж олгох; *удирдан чиглүүлэх; чиглүүлэн явуулах.*

ЧИГЛЭЛ чиглэх үйлийн нэр; *чиглэл өгөх; ямар чиглэлтэй байна даа?*

ЧИГЛЭЛТ чиглэл; *ажлын чиглэлт.*

ЧИГЛЭРҮҮЛЭХ чиглэрэхийн үйлдүүлэх хэв; *хүчээ чиглэрүүлэх.*

ЧИГЛЭРЭХ 1. чигжрэх; 2. чигээ олох.

ЧИГЛЭХ I 1. чиг шулуун болюх, зүглэх; **чиглэх зүглэх** х о р ш.; баруун зүг чиглэж явав; 2. шийдэх, шулуудах.

ЧИГЛЭХ II хүн мал, юмны хугарсан, бэртсэн газарт нь чиг барьж боох.

ЧИГЛЭХ III чигжих.

ЧИГНҮҮЛЭХ чигнэхийн үйлдүүлэх хэв.

ЧИГНҮҮР жигнүүр.

ЧИГНЭХ жигнэх.

ЧИГТЭЙ 1. чиг бүхий юм; 2. шулуун шудрага.

ЧИГЧ үйл явдал шудрага, үнэнч; **чигч үнэнч, чигч шудрага** х о р ш..

ЧИГЧИЙ хүний гар хөлийн хуруууны хамгийн жижиг хуруу; *чигчий хуруу; чигчий хуруууны чинээн том.*

ЧИГЧИЙЛҮҮЛЭХ чигчийлэхийн үйлдүүлэх хэв.

ЧИГЧИЙЛЭХ шүдний завсар орсон юмыг чигчлүүрээр цэвэрлэх; *шүд чигчийлэх.*

ЧИГЧЛҮҮР, шүдний завсар орсон юмыг арилгах ухуур; *шүдний чигчлүүр; ясан чигчлүүр.*

ЧИДУН: чидун жимс у р г а м а л модны хальс ногоон, цэцэг цагаан, анхилмал үнэртэй нэг зүйл ургамал, үүнээс тос гаргаж авна.

ЧИЖИН: чижин хас огт өө сэвгүй, хээ сайхан хас чулуу.

ЧИЙ I уртын хэмжээ, арван цун буюу 0,32 метртэй тэнцэнэ.

ЧИЙ II юманд гялалзам өнгө оруулах нэгэн зүйл будаг; *чий маажин*

ЧИЙГ баахан нойтхон; **чийг нойтон** х о р ш.; **чийг даах** (газраас чийг нойт дээш дааварлах, нэвчих); **чийг болох** (чийгтэй болох, чийг орох); **чийг авах** (чийгтэй болох, нойтон болох, норох, чийгтэх); **чийг татах** (биедээ чийг шингээх, чийг авах, чийгтэх); **чийг амсах** (ялимгүй чийгтэй болох); **чийг амьсах** (чийгтэй мэт сэрүү татаж сэрэгдэх): **хар чийг** (шөнийн цагт буух усан шүүдэр); **чийг бам** (витамин дутагдсанаас үүсэх нэг зүйл өвчин).

ЧИЙГДЭХ хэтэрхий чийгтэй болох.

ЧИЙГЛҮҮЛЭХ чийглэхийн үйлдүүлэх хэв.

ЧИЙГЛЭХ юмыг баахан норгож чийгтэй болгох.

ЧИЙГТҮҮЛЭХ чийгтэхийн үйлдүүлэх хэв, чийгтэй болгох.

ЧИЙГТЭЙ чийг бүхий; *чийгтэй газар; чийгтэй эсгий; чийгтэй даавуу.*

ЧИЙГТЭХ 1. эд юм баахан нойтон болох; 2. хүн амьтны биед витамин дутагдсанаас болж өвдөх.

ЧИЙГЧ: чийгч хорхой а м ь т а н чийгтэй газар орших олон хөлтэй шавьж, чийгийн хорхой ч гэдэг.

ЧИЙДЭН цахилгаан гэрэл; **гэрэл чийдэн** х о р ш.; *чийдэнгийн шил; чийдэнгийн унтраалга; чийдэнгийн утас;* **гар чийдэн** (гарт барьж явах авсаар чийдэн).

ЧИЙР I амьтны явсан мөр, чарга.

ЧИЙР II: **чихэн чийр болох** чихэнд дуу чимээ сонсдох зэргээр түвэгшээл болох.

ЧИЙР III чийрэг, чадмаг, зориг хатуужилтай; *чийртэй залуу; чийртэй үрээ; чийр сайтай мал.*

ЧИЙРМЭГ чийрэг.

ЧИЙРС (ЭН) 1. тариалангийн газар ургах нэгэн зүйл бүдүүн өвс; 2. энэ өвсөөр сүлжиж хийсэн юм; *чийрсэн дэвүүр; чийрсэн малгай; чийрсэн дэвсгэр.*

ЧИЙРЭГ хатуу бат буюу хүчирхэг чадалтай юм; **хатуу чийрэг, бат чийрэг** х о р ш.; *чийрэг бөх; чийрэг морь; чийрэг эд.*

ЧИЙРЭГДЭХ хэтэрхий чийрэг болох.

ЧИЙРЭГЖИХ чийрэг болох.

ЧИЙРЭГЖҮҮЛЭХ чийрэгжихийн үйлдүүлэх хэв; *биеэ чийрэгжүүлэх.*

ЧИЙРЭГШИХ улам чийрэг болох, чийрэг шинжтэй болох.

ЧИЙРЭГШҮҮЛЭХ чийрэгшихийн үйлдүүлэх хэв, чийрэгжүүлэх.

ЧИЙТҮҮ банз болгож зүсхээр дөрвөлжилж зассан дүнз мод.

ЧИЙХРАХ хөлс баахан гарах; *хөлс чийхрах.*

ЧИЛГЭР хатуу, чийрэг; **хатуу чилгэр** х о р ш..

ЧИЛГЭРШИХ хатаж хатуу болох; *чилгэршсэн хатуу мод; чилгэршсэн хатуу ааруул хурууд.*

ЧИЛГЭРШҮҮЛЭХ чилгэршихийн үйлдүүлэх хэв.

ЧИЛГЭХ мод зэргийн нойтон чийгтэй юм эвэрч хатах, хуурай болох; *мод чилгэх; банз чилгэх.*

ЧИЛГЭЭХ чилгэхийн үйлдүүлэх хэв; *нойтон мод тусгайлан чилгээх.*

ЧИЛДГЭР арьс шир зэргийн юмны царьдгар базаахгүй байдал; *чилдгэр арьс; чилдгэр үдээр.*

ЧИЛДИЙХ 1. арьс шир зэргийн чилдгэр болох; 2. ш и л ж с э н чилийсэн цаг хугацаа урт удаан болох; *чилдийсэн урт өдөр.*

ЧИЛДЭН: чилдэн хар маш бараан өнгөтэй юм; *чилдэн хар царайтай.*

ЧИЛИЙЛГЭХ чилийхэд хүрүүлэх.

ЧИЛИЙХ I чилгэр болох.

ЧИЛИЙХ II я р и а түргэн зугадан одох, *түргэн чилийх.*

ЧИЛИЙХ III урт болох; *өдөр чилийх; чилийсэн хавар болов.*

ЧИЛҮҮР хүндэтгэвэл зохих хүний бие өвдөх, санаа сэтгэл зовохы нь; *лагшин чилүүр; сэтгэл нь чилүүртэй байгаа бололтой.*

ЧИЛЭХ 1. хөших, бадайрах, минчүүрэх, чинэх, чинэрэх; *нүд чилэх; гар чилэх; булчин чилэх;* 2. хүндэтгэвэл зохих хүний бие чилүүр болох.

ЧИЛЭЭ хүндэтгэвэл зохих хүнд туссан өвчин; *чилээтэй; чилээ хурчээ;* 2. шаналгаа, зовнил, эвэршээл; *биеийхээ чилээ гаргах.*

ЧИЛЭЭРХЭХ хүндэтгэвэл зохих хүний өвдөх.

ЧИЛЭЭРЭХ чилээрхэх, өвчин хүрэх.

ЧИЛЭЭХ чилэхэд хүрүүлэх, зовниулах, ядруулах.

ЧИМҮҮЛЭХ чимэхийн үйлдүүлэх хэв.

ЧИМХ маш бага; **үмх чимх, атга чимх** х о р ш.; *чимх тамхи; чимх давс; чимх будаа.*

ЧИМХИЙЛГЭХ чимхийхэд хүрүүлэх.

ЧИМХИЙХ хүний бие махбодын энд тэнд гэнт час час хийж өвдөх; *хурууны өндөг чимхийв.*

ЧИМХЛҮҮЛЭХ 1. чимхлэхийн үйлдүүлэх хэв; 2. чимхлэгдэх.

ЧИМХЛҮҮР жижиг сажиг ажиллагаа төвөг ихтэй няхуур ажил; *чимхлүүр оёдолтой.*

ЧИМХЛЭГДЭХ чимхлэхийн үйлдэгдэх хэв.

ЧИМХЛЭХ 1. байн байн чимхэх; 2. ш и л ж с э н аливаа юмыг гамнаж бага багаар хэмнэн хэрэглэх; 3. ш и л ж с э н хурга ишиг зэрэг төл мал өвс ногоо бага сага идэх.

ЧИМХҮҮЛЭХ чимхэхийн үйлдүүлэх хэв.

ЧИМХҮҮН жихүүцмээр хүйтэн; *чимхүүн хүйтэн жавар.*

ЧИМХҮҮР 1. юмыг хавчих чимхэх хэрэгсэл; *сахлын чимхүүр;* 2. ш и л ж с э н бага багаар удаан хугацаанд хийх няхуур ажил; *энэ ажил бол их чимхүүр ажил байгаа юм.*

ЧИМХЭЛХИЙЛЭХ 1. нэн олон чимхэх; 2. онц хэмнэн хэрэглэх.

ЧИМХЭР гутал, оймсны хараанд хийх угалз янзлал.

ЧИМХЭРЛҮҮЛЭХ чимхэрлэхийн үйлдүүлэх хэв.

ЧИМХЭРЛЭХ чимхэр хийх, чимхээрлэх.

ЧИМХЭХ I 1. нэг гарын хөөр хуруугаар юмыг хавчих ба хавчиж авах; 2. өрөлбө бахь зэргийн хавчдаг юмаар юмыг хазуулж хавчих; **чимхэх хавчих** х о р ш.. ᠴᠢᠮᠬᠡᠬᠦ

ЧИМХЭХ II юмны захыг өөр юмаар эмжих; **эмжих чимхэх** х о р ш..

ЧИМХЭХ III бусдыг битүүгээр шоглох, хорсгох, хорлох; *би түүнийг нилээд сайн чимхсэн дээ.*

ЧИМХЭЭР юманд гоёх бэхлэхийн учир хийсэн мөшгөөр эмжээр мэт зүйл; **эмжээр чимхээр** х о р ш.. ᠴᠢᠮᠬᠡᠭᠡᠷ

ЧИМХЭЭРЛҮҮЛЭХ чимхээрлэхийн үйлдүүлэх хэв. ᠴᠢᠮᠬᠡᠭᠡᠷᠯᠦᠦᠯᠬᠦ

ЧИМХЭЭРЛЭХ эмжээрлэх, мөшгөөрлөх. ᠴᠢᠮᠬᠡᠭᠡᠷᠯᠡᠬᠦ

ЧИМЧИГНҮҮЛЭХ чимчигнэхийн үйлдүүлэх хэв. ᠴᠢᠮᠴᠢᠭᠨᠦᠦᠯᠬᠦ

ЧИМЧИГНЭХ 1. халсан, шалбарсан зэргийн шарх эрхрэн өвдөх; *түлсэн газар чимчигнэж байна;* 2. халуун хурц амтанд хэл ам хорсох дарвигнах; *хэл чимчигнэх; уруул чимчигнэх.* ᠴᠢᠮᠴᠢᠭᠨᠡᠬᠦ

ЧИМЭГ гоо сайхан болгоход хэрэглэх зүйл; *толгойн чимэг; хүзүүний чимэг; шүрэн чимэг; ясан чимэг; алтан чимэг;* **оройн чимэг** (эмэгтэйчүүдийн толгойд зүүх чимэг); **цол чимэг** (юманд олгосон цол зэргийн дээр улам өрнөх, бадрах, батжихын бэлэгдэл болгосон үгс; *улсын наадамд түрүүлсэн бөхөд арслан цол, улам өсөх чимэг олгов);* **чимэг үг** (утга зохиолд яруу сайхан болгохын учир оруулсан үгс). ᠴᠢᠮᠡᠭ

ЧИМЭГГҮЙ үзэмж муутай, сайхан биш; *чимэггүй үг чихэнд чийр.* ᠴᠢᠮᠡᠭ ᠦᠭᠢ

ЧИМЭГДЭХ чимэхийн үйлдэгдэх хэв. ᠴᠢᠮᠡᠭᠳᠡᠬᠦ

ЧИМЭГЛҮҮЛЭХ чимэглэхийн үйлдүүлэх хэв. ᠴᠢᠮᠡᠭᠯᠦᠦᠯᠬᠦ

ЧИМЭГЛЭЛ чимэглэсний нь; *тайзны чимэглэл; баярын чимэглэл.* ᠴᠢᠮᠡᠭᠯᠡᠯ

ЧИМЭГЛЭЛТ чимэглэх үйлийн нэр, чимэглэл; *баярын чимэглэлт.* ᠴᠢᠮᠡᠭᠯᠡᠯᠲ

ЧИМЭГЛЭХ чимэх, гоёх, янзлах; *хурлын байр чимэглэх.* ᠴᠢᠮᠡᠭᠯᠡᠬᠦ

ЧИМЭГТ чимэгтэй. ᠴᠢᠮᠡᠭᠲᠡ

ЧИМЭГТЭЙ чимэг бүхий; **чихэнд чимэгтэй үг** (сайхан үг). ᠴᠢᠮᠡᠭᠲᠡ ᠦᠭ

ЧИМЭГЧ 1. тайзны заслал чимэглэлийг эрхлэгч хүн; 2. засдаглах зантай хүн. ᠴᠢᠮᠡᠭᠴᠢ

ЧИМЭРХЭГ 1. биеэ хэтэрхий хэвцрээр янзалж засдаг хүн; 2. биеэ дээгүүрт аваачих ихэрхэг зантай хүн. ᠴᠢᠮᠡᠷᠬᠡᠭ

ЧИМЭХ 1. юманд чимэг хийж янзлах; *тайз чимэх; тасалгаа чимэх; эдээр биеэ чимснээс эрдмээр биеэ чимсэн нь дээр* х у у ч; 2. аливаа буруу муу халхалж, урчлан засдаглаж хэлэлцэх; **гоёх чимэх, чимэх янзлах** х о р ш.. ᠴᠢᠮᠡᠬᠦ

ЧИМЭЭ 1. юмнаас гарсан дуу анир; **чимээ анир** х о р ш.; *салхины чимээ; тэрэгний чимээ; чимээ гаргах; хөлийн чимээ;* **чимээ намхруулагч** (алив машина механизм зэрэг юмны дуу багасгаж намхруулах хэрэгсэл); **чимээ авах** (дуу анир, сураг мэдээ дам сонсох); **чимээ өгөх** (мэдээ чимээ, дохио тэмдэг мэдэгдэх); **чимээ чагнах** (чимээ анир сонсохыг чих тавьж хүсэх); **чимээ имээгүй** (а. чив чимээгүй; *чимээ имээгүй суув; чимээ имээгүй болов;* б. огт мэдээ сураггүй, таг чимээгүй ч гэдэг); 2. сураг мэдээ; **мэдээ чимээ, сураг чимээ, чимээ ажиг** х о р ш.. ᠴᠢᠮᠡᠭ

ЧИМЭЭГҮЙ 1. дуу аниргүй буюу нам гүм; *багшийг орж ирмэгц сурагчид чив чимээгүй болов;* 2. юмны сураг мэдээгүй; *манай хүү сангийн аж ахуйд ажиллахаар яваад бүтэн нэг сар мэдээ чимээгүй болов.* ᠴᠢᠮᠡᠭ ᠦᠭᠢ

ЧИМЭЭЛҮҮЛЭХ чимээлэхийн үйлдүүлэх хэв. ᠴᠢᠮᠡᠭᠯᠦᠦᠯᠬᠦ

ЧИМЭЭЛЭХ чимээ гаргах, мэдээ сураг гаргах хүргэх. ᠴᠢᠮᠡᠭᠯᠡᠬᠦ

ЧИМЭЭТ чимээтэй. ᠴᠢᠮᠡᠭᠲᠡ

ЧИМЭЭТЭЙ 1. чимээ бүхий, чимээ ихтэй 2. сурагтай, мэдээтэй; 3. аливаа үйл явдлын сүр дуулиа ихтэй; *манай бригадад нилээд их чимээтэй нэг хурим болов.* ᠴᠢᠮᠡᠭᠲᠡ ᠮᠥᠨ

ЧИН I нэгэн зүйл хөгжим, харангатай адил бөгөөд жижиг, хүзүүндээ зүүж цохино. ᠴᠢᠨ

ЧИН II а м ь т а н цагаан өрөвтэй адил бөгөөд баахан бага, усанд сууж загас идэх нэгэн зүйл шувуу. ᠴᠢᠨ

ЧИН III 1. огт хуурмаггүй туйлын үнэн; *чин үнэн; чин шударга; чин зүрх; чин санаа;* 2. татгалзаагүй; *чин зориг; чин бат байна;* 3. өөр зан санаагүй; *чин гэж хүснэ; чин гэж батална;* ☆ **чин ван** х у у ч и р с а н (урьдын цагт эзэн хааны угсааны тэргүүн зэрэг хэргэм). ᠴᠢᠨ ᠸᠠᠩ

ЧИНГЭЛЭГ гэрийн гадаа тавьж юм хум агуулахаар хийсэн томоохон авдар. ᠴᠢᠩᠭᠡᠯᠡᠭ

ЧИНГЭНҮҮЛЭХ чингэнэхийн үйлдүүлэх хэв. ᠴᠢᠩᠭᠡᠨᠦᠦᠯᠬᠦ

ЧИНГЭНЭХ төмөрлөг зэрэг юмны жингэнэн дуугарах, жингэнэх. ᠴᠢᠩᠭᠡᠨᠡᠬᠦ

ЧИНГЭР: хангир чингэр хийх төмөрлөг зэрэг хатуу юмны харжиг хуржиг гэсэн дуу чимээ сонсдох. ᠴᠢᠩᠭᠡᠷ

ЧИНЖАЛ; чинжал хутга хоёр талдаа иртэй нэг зүйл хутга. ᠴᠢᠨᠵᠠᠯ

ЧИНЖАЛДАХ чинжалаар хатгах, огтлох. ᠴᠢᠨᠵᠠᠯᠳᠠᠬᠤ

ЧИНЖҮҮ ургамал гашуун бөгөөд халуун чанартай нэгэн зүйл ногоо, идшинд хэрэглэнэ. ᠴᠢᠨᠵᠦᠦ

ЧИНИЙ чи гэдэг төлөөний үгийн харьяалахын тийн ялгалын хэлбэр; *чиний бие; чиний юм.* ᠴᠢᠨᠢ

ЧИНИЙХ чиний гэдэгт хамаатуулах үг; *энэ ном чинийх; энэ хоол чинийх.* ᠴᠢᠨᠢᠶᠬᠡ

ЧИНХЭР паалан будаг. ᠴᠢᠨᠬᠡᠷ

ЧИНЭГ эдэлсэн хэрэглэсэн юм нь хээ сайхан хүн; *чинэг хүн.* ᠴᠢᠨᠡᠭ

ЧИНЭРҮҮЛЭХ чинэрэхийн үйлдүүлэх хэв. ᠴᠢᠨᠡᠷᠡᠭᠯᠡᠬᠦ

ЧИНЭРЭХ чинэх, бадайрах; *нүүр чинэрэх; гар чинэрэх.* ᠴᠢᠨᠡᠷᠡᠬᠦ

ЧИНЭХ хавдах сэлхрэх буюу хор цугларан багтан ядах мэтээр минчүүрэн өвдөх, чинэрэх; *нүдний ухархайгаар чинэж өвдөх; боосон хуруу чинэх; хөх чинэх.* ᠴᠢᠨᠡᠬᠡ

ЧИНЭЭ (Н) I 1. хүний биед байгаа хүч чадал, чадвар мэдлэгийн хир хэмжээ; *хүч чинээ; чадал чинээ; хир чинээ; мэдцийн чинээгээр;* 2. хүний хөрөнгө амьдралын хир хэмжээ; *хөрөнгө чинээ сайтай; чинээ ядуу, хогшил зэхий;* **чинээгээрээ** (хир чадал боломжоороо; *чинээгээрээ хөдлөх; чадах чинээгээрээ ажиллах).* ᠴᠢᠨᠡᠡ

ЧИНЭЭ (Н) II аливаа юмны хэмжээг заах үг; *уулын чинээн биетэй, туулайн чинээн чихтэй, аягын чинээн нүдтэй* (үлгэрээс); *өдий чинээ; төдий чинээ;* **чинээнд нь тултал, чинээнд нь хүртэл** (алив юмыг мохоолд нь хүргэх *чинээнд нь хүртэл эрэгдэв).* ᠴᠢᠨᠡᠡ

ЧИНЭЭГҮЙ 1. хүн амьтны хүч чадал дорой ядуу; 2. хөрөнгө амьдралаар мөхөс дутуу; *хөрөнгө чинээгүй ядуу зүдүү амьдарч байв.* ᠴᠢᠨᠡᠡᠭᠦᠢ

ЧИНЭЭЖИХ 1. хөрөнгө чинээ сайтай болох; 2. хүч чадалтай болох. ᠴᠢᠨᠡᠡᠵᠢᠬᠦ

ЧИНЭЭЖҮҮЛЭХ чинээжихийн үйлдүүлэх хэв ᠴᠢᠨᠡᠡᠵᠢᠬᠦᠯᠡᠬᠦ

ЧИНЭЭЛЭГ хөрөнгө амьдралаар элбэг, хангалуун; *чинээлэг айл; чинээлэг амьдрал.* ᠴᠢᠨᠡᠡᠯᠡᠭ

ЧИНЭЭРХЛЭХ чинээрхэх. ᠴᠢᠨᠡᠡᠷᠬᠡᠯᠡᠬᠦ

ЧИНЭЭРХҮҮ чинээ чадал сайтай. ᠴᠢᠨᠡᠡᠷᠬᠦᠦ

ЧИНЭЭРХҮҮЛЭХ чинээрхэхийн үйлдүүлэх хэв. ᠴᠢᠨᠡᠡᠷᠬᠦᠦᠯᠡᠬᠦ

ЧИНЭЭРХЭГ 1. хүний тэнхээ чадал үлэмж; 2. хөрөнгө хогшил ихээхэн; 3. бардам дээрэнгүй. ᠴᠢᠨᠡᠡᠷᠬᠡᠭ

ЧИНЭЭРХЭХ чинээрхэг зан байдал гаргах. ᠴᠢᠨᠡᠡᠷᠬᠡᠬᠦ

ЧИНЭЭТЭЙ 1. чадал тэнхээ сайтай; 2. амьдрал байдал сайтай. ᠴᠢᠨᠡᠡᠲᠡᠶ

ЧИНЭЭХ чинэхэд хүрүүлэх. ᠴᠢᠨᠡᠬᠡ

ЧИРГҮҮЛ чирч явахад тохируулж хийсэн зүйл; *машины чиргүүл; чиргүүл тэрэг.* ᠴᠢᠷᠭᠦᠦᠯ

ЧИРГҮҮЛДЭХ чирэгдэж явах. ᠴᠢᠷᠭᠦᠦᠯᠳᠡᠬᠦ

ЧИРГҮҮЛЭХ 1. чирэхийн үйлдүүлэх хэв; 2. чирэгдэх. ᠴᠢᠷᠭᠦᠦᠯᠡᠬᠦ

ЧИРД: чирд гэх, чирд хийх түргэн зуур чир чир хийж дуугарах. ᠴᠢᠷᠳ

ЧИРҮҮЛ чирэх юм; *чиргүүл тэрэг; чиргүүл завь.* ᠴᠢᠷᠦᠦᠯ

ЧИРҮҮЛЭХ 1. чирэхийн үйлдүүлэх хэв; 2. чирэгдэх. ᠴᠢᠷᠦᠦᠯᠡᠬᠦ

ЧИРХРЭХ бархирах; **бархирах чирхрэх** хорш.. ᠴᠢᠷᠬᠢᠷᠡᠬᠦ

ЧИРЭГДҮҮЛЭХ чирэгдэхийн үйлдүүлэх хэв, чирэгдэл болгох. ᠴᠢᠷᠡᠭᠳᠦᠦᠯᠡᠬᠦ

ЧИРЭГДЭЛ чирэгдэх үйлийн нэр; **үрэгдэл чирэгдэл, чирэгдэл сүйтэл** хорш.; *чирэгдэл ихтэй.* ᠴᠢᠷᠡᠭᠳᠡᠯ

ЧИРЭГДЭХ 1. чирэхийн үйлдэгдэх хэв; 2. бусдын үйл хэрэг уршиг нөлөөнд татагдах холбогдох зэргээр эд хөрөнгө үрэгдэх, сүйдэх, бие зовох зүдэх; *урьдын цагт өртөөний албанд чирэгдэж байв.* ᠴᠢᠷᠡᠭᠳᠡᠬᠦ

ЧИРЭГЧ чирдэг юм. ᠴᠢᠷᠡᠭᠴᠢ

ЧИРЭХ 1. юмыг гулдарч татах; **чирэх гулдрах** хорш.; *тэрэг чирэх; мод чирэх;* 2. бусдыг төвөгтэй үйл ажилд дагуулах учруулах; *гай тотгор чирэх; энэ ч их л төвөг чирэх ажил байна даа.* ᠴᠢᠷᠡᠬᠦ

ЧИСҮҮ нэгэн зүйл торгомсог бараа, чичүү ч гэдэг; *хятад чисүү; орос чисүү.* ᠴᠢᠰᠦᠦ

ЧИХ (ЭН) I 1. сонсох эрхтэн; *сонор чих; соотон чих; хулгар чих; дэлхий дээгүүр дэгдэн байдаг, дэлдэн чихтэй туулай дөрвөн жил* (дуу); **чихний хуудас** (чихний дэлбэ); **чихний язгуур** (чихний арын уг): **чихний ёроол** (хүний чихний хонгилын дотоод эсрэг үзэгдэх газар(; **чихний омог** (чихний мөрийн дээд эргээд); **чихний хөвөө** (чихний дэлбийн тойрсон ирмэг); **чихний ухуур** (чихний хулхийг ухахад зориулсан хэрэгсэл); **чихний унжлага** (чихний

гэдэл); **чихний дэлбэ** (чихний бүгд төлөв); **чихний цэцэг** (зарим хүний чихэн дээр байдаг шовгор юм); **чихний гэдэс** (чихний унжлага): **чихний хулхи** (чихний дотоодоос гарах хаг мэт юм); **чихний дэлбэг** (чихний хуудас); **чихний сүв** (чихний дотоод нүх); **чихний сүйх** (эмэгтэйчүүдийн чихэндээ зүүх чимэг ээмэг); **чих булагтах** (чихний дотор өвдөж идээлэх); 2. сонсгол; **чих сонор** (а. сонсохдоо сайн: б. юм хумыг дуулж мэдэхдээ авьяастай); **чих цохих** (дам сонсож мэдэх); **чих тавих** (а. сураг мэдээ сонсохыг хичээх; *алдсан адууныхаа хойноос чих тавьж байв;* б. анхааран сонсох; *багшийн заасан хичээлийг чих тавин сонсож байв);* **чихэн чийр** (дуу ба үг ярианы сонсоход тааламжгүйгий нь); **нүдэн балай, чихэн дүлий** (юү ч үзээгүй, юү ч сонсоогүй); **нэг чихээрээ сонсоод, нөгөө чихээрээ гаргах** (хялбар мартах). ᠴᠢᠬᠦ

ЧИХ II зарим юмны хажууд дэлбийж гарсан чих мэт юм, бариул; *авдрын чих; хавчигны чих;* **малгайн чих** (чих хамгаалахад зориулж малгайд хийсэн, сөхдөг буулгадаг зүйл); **тэрэгний чих** (үхэр, морь, тэмээн тэрэгний хүрдний нүхнээс гадагш илүү гарсан голын хоёр үзүүр); **чих цүү** (тэрэгний тэнхлэгийн хүрдний нүхнээс гадагш гарсан голын хоёр үзүүрт торгох гадас): **тогооны чих** (тогоог барихад зориулж хийсэн дэлбэ бариул); **бүрхээрийн чих** (бүрхээрийн хоёр этгээдэд архины тосуур хувинг дүүжлэхэд зориулан гаргасан тээглүүр); ☆ **бууны чих** (замаг буугны гол төмрийн гадна талд дарь тавьж авалцуулах бяцхан хонхортой хэсэг); **чихэн боов** (гурилаар хийсэн нэг зүйл боов).

ЧИХ III тарьсан тарианы анх цухуйсан ногоогий нь; *тарианы чих цухуйж байна.*

ЧИХДҮҮЛЭХ чихдэхийн үйлдүүлэх хэв. ᠴᠢᠬᠳᠦᠭᠦᠯᠡᠬᠦ

ЧИХДЭХ чихнээс барих, татах; *эр хүн гэнэнгүй нь дээр гэж эцсэн морио чихдэх.* ᠴᠢᠬᠳᠡᠬᠦ

ЧИХЛҮҮЛЭХ чихлэхийн үйлдүүлэх хэв. ᠴᠢᠬᠯᠦᠭᠦᠯᠡᠬᠦ

ЧИХЛЭХ I тарьсан тарианы анх ногоо гарах; *тариа чихлэх.* ᠴᠢᠬᠯᠡᠬᠦ

ЧИХЛЭХ II юманд чих хийх, *малгай чихлэх.*

ЧИХЛЭХ III байн байн чихэх.

ЧИХМАЙ 1. хүнд чамбай юм; *чихмай жинтэй юм;* 2. санаа бодлого гүн, үйл явдал болгоомжтой; *чихмай хүн;* 3. хүний дүр байдал үзэсгэлэнтэй, жавхлантай сайхны нь; *чихмай сайхан авсай билээ.* ᠴᠢᠬᠮᠠᠢ

ЧИХРЭГ мод төмөр зэргийн юм, нүх сүв заадас завсарт багтахгүй чаргагий нь. ᠴᠢᠬᠷᠡᠭ

ЧИХРЭХ чихрэг чаргаг болох. ᠴᠢᠬᠷᠡᠬᠦ

ЧИХТ чихтэй I. ᠴᠢᠬᠲᠡ

ЧИХТЭЙ I чих бүхий юм; *сонор чихтэй; хулгар чихтэй; чихтэй тогоо; чихтэй хавчиг.* ᠴᠢᠬᠲᠡᠶ

ЧИХТЭЙ II хулангийн өөр нэр, хээрийн луус ч гэдэг; **хулан чихтэй** х.о р ш.; *хулан чихтэй мэт хурдан.*

ЧИХҮҮЛЭХ 1. чихэхийн үйлдүүлэх хэв; 2. чихэгдэх. ᠴᠢᠬᠦᠭᠦᠯᠡᠬᠦ

ЧИХҮҮР алив юмыг далдлан чихэх зантай. ᠴᠢᠬᠦᠷ

ЧИХЦЭЛДҮҮЛЭХ чихцэлдэхийн үйлдүүлэх хэв. ᠴᠢᠬᠴᠡᠯᠳᠦᠭᠦᠯᠡᠬᠦ

ЧИХЦЭЛДЭХ хэтэрхий чихцэх. ᠴᠢᠬᠴᠡᠯᠳᠡᠬᠦ

ЧИХЦЭХ цухал, багтаамж муутай газарт чихэлдэн шахцаж түдгэлзэх, багтаж ядах. ᠴᠢᠬᠴᠡᠬᠦ

ЧИХЭВЧ чихэндээ өмсөх хувцас, юм. ᠴᠢᠬᠡᠪᠴᠡ

ЧИХЭГДЭХ 1. чихэхийн үйлдэгдэх хэв; 2. бусдын хийсэн үйл хэрэгт мушгиугаар тулгагдан холбогдох; *хэрэгт чихэгдэх.* ᠴᠢᠬᠡᠭᠳᠡᠬᠦ

ЧИХЭЛ торго дурдан зэрэг юмны хатуухны нь. ᠴᠢᠬᠡᠯ ᠵ

ЧИХЭЛДҮҮР малд тохиолдох нэг зүйл өвчин, гэдэс нь ихэд дүүрч хэвтэх, босох, хөрвөх зэргээр тэсч ядан зовуурлах өвчин. ᠴᠢᠬᠡᠯᠳᠦᠷ

ЧИХЭЛДЭХ 1. чихцэх, шахцах; *чихэлдэж шахцалдсаны хэрэггүй;* 2. ш и л ж сэ н чихэлдүүр өвчин тохиолдох. ᠴᠢᠬᠡᠯᠳᠡᠬᠦ

ЧИХЭЛТ чихэх үйлийн нэр. ᠴᠢᠬᠡᠯᠲ

ЧИХЭЛЦЭХ чихэхийн үйлдэлцэх хэв. ᠴᠢᠬᠡᠯᠴᠡᠬᠦ

ЧИХЭР I хүн амьтны нүдний цэцгий цагаавтры нь; цэхэр ч гэдэг. ᠴᠢᠬᠡᠷ

ЧИХЭР II тусгай манжингаас ялгаруулан авдаг цагаан өнгөтэй бөгөөд амтлаг тэжээлийн талст бодис; *хэлэн дээр нь чихэр тавьж, хүзүүн дээр нь хутга тавих* з ү й р; **чихрийн лууван** (чихэр хийдэг нэг зүйл лууван): **элсэн чихэр** (жижиг талст чихэр); **мөсөн чихэр** (мөс мэт хатуу том чихэр); **цаастай чихэр** (бага багаар цаасанд ороож хийсэн чихэр); **чихрийн үйлдвэр** (янз бүрийн чихэр үйлдвэрлэх үйлдвэр); **чихэр амт** (тааламжтай сайхан амт), **чихэр шиг үг** (сайхан үг; *чихэнд чинь*

чихэр шиг үг хэлье); **чихэр өвс** ургамал (40—70 см. өндөр ургадаг олон наст өвсөрхөг ургамал, цэцгийн өнгө ягаавтар, хавар тэмээ бага зэрэг иднэ, намар хонь ямаа бага сага иднэ, үндэс нь чихэр амттай, эмнэлэгт хэрэглэнэ).

ЧИХЭРЛҮҮЛЭХ чихэрлэхийн үйлдүүлэх хэв.

ЧИХЭРЛЭХ чихэртэй болгох.

ЧИХЭРХҮҮ 1. чихэрхэг; 2. чих мэт.

ЧИХЭРХЭГ чих ихтэй, том чихтэй.

ЧИХЭХ 1. сав суулгад юм хумыг хүчдэн багтааж хийх, шахцан багтаж орох; *шүудайд ноос чихэх; байшин гэрт хүн амьтан чихэх;* 2. ямар нэгэн үйл хэргийг бусдад тулган түлхэж хүлээлгэх; *хэрэг чихэх; ажил чихэх.*

ЧИЧИГДЭХ чичихийн үйлдэгдэх хэв, бусдад гадуурхагдан түлхэгдэх ба дарлагдах, доромжлогдох; *нүд чичигдэх.*

ЧИЧИГНҮҮЛЭХ чичигнэхийн үйлдүүлэх хэв.

ЧИЧИГНЭХ 1. байн байн баахан хөдлөх, салганах, салгалах; *өвдөг чичигнэх;* 2. үг хэлэхэд түгдчин тулгарч сандрах; *хэл чичигнэх.*

ЧИЧИРХИЙЛЭХ хилэгнэснээс буюу өвчин хийгээд нас хөгширсөн зэргээс гар хөл, бие догдлон хөдлөх, салганах, салганах.

ЧИЧИРХЛЭХ даарч жихүүцэх, өвдөж доройтсоноос болж бие дагжин хөдлөх.

ЧИЧИХ 1. юмны үзүүрээр хатгах, шаах; *хутгаар чичих; шороор чичих;* 2. гадуурхан үзэх; *та намайг ямагт нүд чичиж байхын хэрэг юу билээ.*

ЧИЧЛҮҮЛЭХ 1. чичлэхийн үйлдүүлэх хэв; 2. чичлэгдэх.

ЧИЧЛЭХ байн байн чичих.

ЧИЧРҮҮЛЭХ чичрэхийн үйлдүүлэх хэв.

ЧИЧРЭГЛЭХ айсан, даарсан зэргээс бие долгисон хөдлөх; *даарч чичрэглэх; айж чичрэглэх.*

ЧИЧРЭЛ чичрэх үйлийн нэр.

ЧИЧРЭХ хүйтэнд даарах, өвчинд автагдах, хэтэрхий айх зэргээс бие дагжин хөдлөх; *даарч чичрэх; айж чичрэх; чичирч дагжих; чичирч бүгэх; зүрх чичрэх; хөл чичрэх.*

ЧИЧҮҮ чисчүү.

ЧИЧҮҮЛЭХ 1. чичихийн үйлдүүлэх хэв; 2. чичигдэх.

ЧИЧҮҮР хатгах чичих хэрэгсэл; ☆ **чичүүр хорхой** амьтан бие хавтгайхан бөгөөд урт, үе үеэр төрсөн, хар толгойтой, хоёр сахалтай, олон хөлтэй, ац сүүлтэй, хүн амьтныг хатгадаг хорхой.

ЧИЧЭЭС мод бургасны анхан цухуйн ургаж байгаа иш.

ЧИЧЭЭСЛЭХ чичээс гарах, ургах.

ЧОГЧГОР зогжгор, авсаархан; *чогчгор залуу.*

ЧОГЧОЙХ чогчгор болох.

ЧОЙЧГОР гадагшаа майга сариу хөлтэй.

ЧОЙЧИЙХ хөл чойчгор болох.

ЧОНО (Н) амьтан нохойн төрлийн сүүн тэжээлт махчин амьтан; **азарган чоно** (эр чоно); **өлөгчин чоно** (эм чоно); **чонын бэлтрэг** (чонын зулзага); **чонын үүр** (чонын орших нүх); **чонын ергөс** ургамал (нийлмэл цэцгийн язгуурын олон наст ургамал, цэцэг хонгор зулын адил, иш өндөр бөгөөд өргөстэй, нуга газраар ургана); **чонын төмс** ургамал (шар цэцэгтэй нэгэн зүйл сараана); **чонын хялгана** ургамал (нэг зүйл ботуул); **чоно халтар** ургамал (зэрлэг ургах нэгэн зүйл ногоо, үнэр сайхан, хүж үнэртэн хийхэд хэрэглэдэг); **чонын элэг** ургамал (мойл мэт үртэй, сондуутай нэг зүйл мод, үрийг идэж болохгүй); **чонын сүүл** ургамал (салаа гүй, навч нь бургасны навч чиг, түүхийгээр идэж болно, амт исгэлэн нэг зүйл ногоо): **чоно яр** (хүний биед хэсэг хэсгээр гарах улаавтар өнгөтэй яр); **чонын хөрвөш** (их загатнаж хэсэг хэсэг гөвдрүүтэх өвчин); **чоно хонь хоёр шиг** (харилцан бие биеэ үзэж чаддаггүй).

ЧОНОГОНО ургамал гол ишгүй, хурц өргөстэй, уртлаг навчтай, үндсэнд нь хөвөн мэт унгарилтай нэгэн зүйл ургамал.

ЧОНОМБАР амьтан барсын адил бөгөөд жижиг, нохой мэт хуцдаг араатан амьтан.

ЧОНОНЦОР амьтан нохойн намын, хөхөөр өсөх араатан, олноороо сүрэглэн явна, ерийн чоноос жижиг, зүс улаавтар, ховор амьтан.

ЧОХОЙ шохой.

ЧОХОЙДОХ шохойдох.

ЧОХОЙДУУЛАХ чохойдохын үйлдүүлэх хэв, шохойдуулах.

ЧӨДӨР 1. морь малын гурван хөлд торгож тогтоодог нэг зүйл хэрэгсэл; **чөдөр тушаа**

х о р ш.; *төмөр чөдөр; суран чөдөр; чөдөр зангидах;* **чөдрийн сум** (чөдрийн урт шилбэ); **чөдрийн хумс** (чөдрийн чагт тээг); **чөдрийн хаа** (чөдрийн өмнөх хоёр салаа); **чөдрийн шилбэ** (чөдрийн сум); **чөдрийн гогцоо** (чөдрийн чагт торгох нүх): **чөдрийн алга** (чөдрийн чагттай хэсэг); **чөдөр холбоо** (нэгэн зүйл гогцоолдсон хөвөрхий уяа); **чөдөр өвс** (мод өвсөнд ороож ургадаг ургамлуудын ерөнхий нэр); **чөдөр ороомог** у р г а м а л (ороонгын төрөлд багтдаг бөгөөд байдал нь утас мэт нарийн, бусад ургамлыг ороож ургадаг, шимэгч ургамал); **чөдөр сэдэргэнэ** у р г а м а л (сэдэргэнийн төрөлд багтах бөгөөд нуга, тариалангийн газар ихэд ургадаг, хогийн ургамал); ☆ **чөдөр төмөр** (винтов бууны замгийн нэг хэсэг); **чөдөр галзуу** (нохойд тохиолдох нэг зүйл өвчин, чөдрөг ч гэдэг); 2. садаа тотгор; *ажлын чөдөр; миний ажилд чөдөр болох хэрэггүй.* ᠴᠥᠳᠥᠷ

ЧӨДӨРЛӨГДӨХ 1. чөдөрлөхийн үйлдэгдэх хэв; 2. бусдын үгэнд хариулж чадахгүй тээглэгдэх, үйл ажилд татагдан хүлээгдэх.

ᠴᠥᠳᠥᠷᠯᠥᠭᠳᠥᠬᠦ

ЧӨДӨРЛӨХ 1. малын хөлд чөдөр торгох; *морь чөдөрлөх;* 2. бусдын үйл ажилд *саад тотгор хийх.* ᠴᠥᠳᠥᠷᠯᠥᠬᠦ

ЧӨДӨРЛҮҮЛЭХ 1. чөдөрлөхийн үйлдүүлэх хэв; 2. чөдөрлөгдөх. ᠴᠥᠳᠥᠷᠯᠥᠭᠦᠯᠬᠦ

ЧӨДӨРТЭЙ чөдөр бүхий; *чөдөртэй морь.*

ᠴᠥᠳᠥᠷᠲᠡᠶ

ЧӨДРӨГ чөдөр галзуу өвчин. ᠴᠥᠳᠥᠷᠡᠭ

ЧӨЛӨӨ 1. уужим зай талбай; *Сүхбаатарын чөлөө; өргөн чөлөө;* 2. завсар завдал; **зав чөлөө** х о р ш.; *ажлын чөлөө завсар; ажлын самбаа чөлөөгөөр хийх ажил;* 3. ажил үйлдвэр хийгээгүй сул үе; *амралтын чөлөө; сул чөлөөтэй сууж байна;* **чөлөө гуйх** (ажил хөдөлмөр хийгчид, ажлаасаа гарах буюу түр хугацаагаар чөлөөлөгдөхийн учир хүсэлтээ гаргах); **чөлөө эрэх** (а. албан ажлаас чөлөө гуйх; б. бусдыг унагаах бодлогоор түүний өө сэвийг эрэлхийлэх; в. үйл ажлаас зай зав олохыг сүвэгчлэх); **чөлөө авах** (ажиллахгүй байх зөвшөөрөл авах); **чөлөө тавих** (ажиллаж байгаа хүмүүс буюу сурагчдад амрах түр хугацаа тавих); **амралтын чөлөө** (амрах хугацаа): **чөлөөний хуудас** (чөлөө олгосныг магадлах бичиг); ☆ **эрх чөлөө** (аливаа анги нийгэмлэгийн зүгээс хязгаарлал, хавчлага шахалтгүйгий нь; *эрх чөлөөгөө олох; эрх чөлөөний хөдөлгөөн).* ᠴᠥᠯᠥᠡ

ЧӨЛӨӨГҮЙ зай завгүй. ᠴᠥᠯᠥᠡ ᠲᠤᠰᠠᠭᠦᠢ

ЧӨЛӨӨЛӨГЧ чөлөөлөх үйлийн нэр; *Зөвлөлтийн чөлөөлөгч арми.* ᠴᠥᠯᠥᠡᠯᠡᠭᠴᠢ

ЧӨЛӨӨЛӨХ 1. ажил үүргээс чөлөө гуйх ба ажил үүргээс нь чөлөө өгөх; 2. эрх чөлөөтэй болгох; *хөрөнгөтний дарлалаас чөлөөлөх.*

ᠴᠥᠯᠥᠡᠯᠡᠬᠦ

ЧӨЛӨӨЛҮҮЛЭХ чөлөөлөхийн үйлдүүлэх хэв. ᠴᠥᠯᠥᠡᠯᠡᠭᠦᠯᠬᠦ

ЧӨЛӨӨТ 1. зав чөлөө бүхий; 2. эрх чөлөө бүхий. ᠴᠥᠯᠥᠡᠲᠡᠶ

ЧӨЛӨӨТЭЙ чөлөө бүхий; *би хэдэн хоногийн чөлөөтэй байна.* ᠴᠥᠯᠥᠡᠲᠡᠶ

ЧӨЛӨӨЧЛӨХ 1. зав чөлөөг олж үйл ажлыг хийх үйлдэх; 2. эзгүйчлэх. ᠴᠥᠯᠥᠡᠴᠢᠯᠡᠬᠦ

ЧӨМӨГ 1. булуут ясны доторхи тосорхог нялцгай нэхмэл; *чөмөг идэх; хурга таргалавч чөмөг нь бор* х у у ч; 2. мөн тосорхог нялцгай нэхмэл бүхий булуут яс; **шагаат чөмөг** (дунд чөмөгний дараах яс); **бугалаг чөмөг** (далын дараах яс); **атгаал чөмөг** (бугалаг чөмөг); **дунд чөмөг** (сүүж ясны дараах чөмөг): **богтос чөмөг** (малын бугалаг чөмөгний дараах яс); **чөмөг таших** (чөмөгний ясыг хагалж доторхи чөмгий нь авах); 2. тарга тэвээрэг **чөмөг суух** (мал гөрөөсний таргалж тэвээрч чөмөг нь нүнжигтэй болох); **чөмөг алдах** (мал гөрөөсний эцэж туранхлаад чөмөг нь нүнжиггүй болох); **чөмөгтэй** (мал гөрөөсний тарга хүч авч өөх нүнжигтэй болох). ᠴᠥᠮᠥᠭ

ЧӨМӨГГҮЙ маш туранхай яданги. ᠴᠥᠮᠥᠭ ᠲᠤᠰᠠᠭᠦᠢ

ЧӨМӨГЛӨХ мал гөрөөсний тарга хүч авч, чөмөг суух. ᠴᠥᠮᠥᠭᠯᠡᠬᠦ

ЧӨМӨГЛҮҮЛЭХ чөмөглөхийн үйлдүүлэх хэв. ᠴᠥᠮᠥᠭᠯᠡᠭᠦᠯᠬᠦ

ЧӨМӨГТЭЙ 1. чөмөг бүхий; 2. хүч тарга сайтай ᠴᠥᠮᠥᠭ ᠲᠡᠶ

ЧӨМӨГЧЛӨХ малын тарга хүчтэйгээс нь сонгон авч хэрэглэх; *хоттой хониноосоо чөмөгчилж идэх; чөмөгчилж худалдах.* ᠴᠥᠮᠥᠭᠴᠢᠯᠡᠬᠦ

ЧӨМӨГЧЛҮҮЛЭХ чөмөгчлөхийн үйлдүүлэх хэв. ᠴᠥᠮᠥᠭᠴᠢᠯᠡᠭᠦᠯᠬᠦ

ЧӨРГӨР туранхай, нарийн, туя муутай юм; *чөргөр хурга; чөргөр уурга.* ᠴᠥᠷᠭᠥᠷ

ЧӨРИЙЛГӨХ чөрийхийн үйлдүүлэх хэв.

ᠴᠥᠷᠢᠶᠯᠭᠡᠬᠦ

ЧӨРИЙХ чөргөр болох. ᠴᠥᠷᠭᠥᠭᠡᠬᠦ

ЧӨРӨГНӨХ чөргөр юмны үргэлжлэн хөдлөх. ᠴᠥᠷᠥᠭᠨᠡᠬᠦ

ЧӨРӨЛЗӨХ чөргөр юмны байн байн хөдлөх. ᠴᠥᠷᠥᠯᠵᠡᠬᠦ

ЧӨТГӨР шашны мухар сүсгийн үүднээс далдуур хорлох чадалтай гэдэг хий юм; **буг**

чөтгөр, чөтгөр шулам х о р ш.; **чөтгөр хорхой, чөтгөр бөөс** (бясаа хорхойн өөр нэр): **чөтгөрийн гал** (хялбар гэрэлтдэг бөгөөд харанхуйд сүүмэлзэн харагддаг химийн махбод; зарим чулуулаг, амьтан, амьтны яс, ургамлын нэхмэл тэргүүтэнд бий, фосфор); **чөтгөрийн идээ** у р г а м а л (жижиг жижиг цэцгүүдтэй нэг зүйл олон наст ургамал). ᠴᠥᠭᠡᠷᠢᠨ

ЧӨХ морь малыг давиран явуулахад өгүүлэх үг. ᠴᠥᠬ

ЧӨЧГӨР нарийн, туягүй, чөргөр юм; *чөчгөр хөлтэй ширээ; чөчгөр саваа.* ᠴᠥᠴᠭᠥᠷ

ЧӨЧИГНӨХ 1. чөчгөр юмны чөчиг чөчиг хөдлөх; 2. салганан хөдлөх, салгалах, чичигнэх. ᠴᠥᠴᠢᠭᠨᠥᠬ

ЧӨЧИЙЛГӨХ чөчийхийн үйлдүүлэх хэв. ᠴᠥᠴᠢᠶᠢᠯᠭᠡᠬ

ЧӨЧИЙХ 1. чөчгөр болох, чөрийх; 2. хүн амьтны гар хөл, модны гишүү мөчир зэргийн салаалан гарсан юмны хөндлөн тийш гозойх, чөрийх. ᠴᠥᠴᠢᠬ

ЧӨЧИЛЗӨХ чөчгөр юмны чөчис чөчис хөдлөх. ᠴᠥᠴᠢᠯᠵᠥᠬ

ЧӨЧИХ 1. хэвцэглэн зөрчих, зөрүүд зан гаргах; *миний өмнөөс ярдаглан чөчих хэрэггүй;* 2. чөчүү, унжуу болох; *чөчүү хормойтой дээл.* ᠴᠥᠴᠢᠬ

ЧӨЧҮҮ 1. хэвцэг, зөрүүд; *чөчүү зан;* 2. унжуу. ᠴᠥᠴᠦᠦ

ЧУГУУЛАХ чуулах, цуглаж зөвлөн хэлэлцэх. ᠴᠤᠭᠤᠯᠠᠬ

ЧУЛУУ (Н) хэсэг хэсгээр буюу бөөн цулаар орших чулуулаг; *өөдөө хаясан чулуу, өөрийн толгой дээр* х у у ч; **эрдэнийн чулуу** (үнэ бүхий чулуулгийн зүйл); **тэмээн чулуу** (хааяа энд тэнд ганц нэгээр онцгой байгаа дэндгэр том чулуу); **адуун чулуу** (нэгэн хэсэг талбай эзэлсэн тархайвтар байдалтай байгаа нилээд томоохон чулуу); **хонин чулуу** (хэсэгхэн газар бөөндүүхэн байгаа, гол төлөв цагаан цайвар өнгөтэй жижгэвтэр чулуу); **үхэр чулуу** (хааяа энд тэнд байгаа нилээд томоохон чулуу); **хайр чулуу** (мөлгөр биш, ир ирмэг ихтэй жижиг чулуу; *хайр чулуун эхт, хатан төмөр эцэгт);* **чулуун зэвсэг** (эрт дээр цагийн чулуугаар үйлдсэн зэвсэг; *хуучин чулуун зэвсэг; шинэ чулуун зэвсэг);* **чулуун бар** (чулуугаар хийсэн бар): **чулуун барч** (чулуун дээр бар сийлэх хүн); **чулуун нүүрс** (газраас малтан гаргах шимийн гаралтай шатах хатуу зүйл); **чулуун нүүрсний уурхай** (чулуун нүүрс гаргаж авах орд); **чулуун давс** (чулуун мэт хатуу давс, жамц давс); **чулуун самбар** (чулуугаар хийсэн самбар); **шулуун шүнх** (чулуугаар хийсэн нэг зүйл будаг); **чулуун ногоц** (зурах, сийлэхэд хэрэглэх нэгэн зүйл будаг); **чулуун хөгц** (өнгө хөх нэгэн зүйл будаг): **чулуу тавих** (чулуугаар мэрэглэх зам үйл хийх; **чулуун зүрхтэй** (хатуу зоригтой, айдаггүй); **чулуу хаях** (хоёр хүний хооронд хов хутгаж хоргол сацах, яс хаях ч гэдэг); **чулуу хөөлгөх** (хуурмаглан дэмий юм хөөцөлдүүлэх); **чулуун дэгдээ** а м ь т а н (далайд орших, хавтгай биетэй, өрөөсөн талдаа нүдтэй нэг зүйл загас). ᠴᠤᠯᠤᠭ

ЧУЛУУДАХ I юмыг шидэх, ширүүн хаях; *энэ саванд хагарах хэмхрэх зүйл бий, битгий чулуудаарай!* ᠴᠤᠯᠤᠭᠳᠠᠬ

ЧУЛУУДАХ II хэтэрхий чулуутай болох; *чулуудаад ухаж болохгүй байна.*

ЧУЛУУДУУЛАХ чулуудахын үйлдүүлэх хэв. ᠴᠤᠯᠤᠭᠳᠤᠤᠯᠬᠤ

ЧУЛУУЖИХ 1. ямар нэгэн юм чулуу болох, чулуурах; *чулуужсан мод;* 2. чулуутай болох. ᠴᠤᠯᠤᠭᠵᠢᠬ

ЧУЛУУЖУУЛАХ чулуужихын үйлдүүлэх хэв. ᠴᠤᠯᠤᠭᠵᠤᠤᠯᠬᠤ

ЧУЛУУЛАГ 1. чулуу ихтэй; *чулуулаг газар;* 2. чулуу; *чулуулгийн дотор ашигт малтмалын зүйл олон бий.* ᠴᠤᠯᠤᠭᠯᠠᠭ

ЧУЛУУРАХ 1. чулуу болох; 2. хатуурах, чулуу мэт болох. ᠴᠤᠯᠤᠭᠤᠷᠬᠤ

ЧУЛУУРХАГ чулуу ихтэй. ᠴᠤᠯᠤᠭᠤᠷᠬᠠᠭ

ЧУЛУУРХУУ 1. чулуурхаг; 2. чулуу мэт. ᠴᠤᠯᠤᠭᠤᠷᠬᠤ

ЧҮЛУУТ чулуу бий. ᠴᠤᠯᠤᠭᠲᠠᠢ

ЧУЛУУТАЙ чулуу бүхий, чулуу ихтэй; *чулуутай газар; чулуутай зам.* ᠴᠤᠯᠤᠭᠲᠠᠢ ᠭᠠᠵᠠᠷ

ЧУЛУУЧ (ИН) чулуугаар юм хийдэг хүн. ᠴᠤᠯᠤᠭᠴᠢᠨ

ЧУЛУУШИХ чулуу шинжтэй болох. ᠴᠤᠯᠤᠭᠰᠢᠬᠤ

ЧУН цайвгар улаан өнгөтэй нэгэн зүйл чулуу; *чун эрх; чун шигтээ.* ᠴᠤᠨ

ЧУУ арай чарай, дөнгөж дангаж; *чуу чамай; арай чуу; чуу чай.* ᠴᠤᠭ

ЧУУЛАЛ чуулах үйлийн нэр; *чуулал болох; чуулалд очих.* ᠴᠤᠯᠠᠯᠭ

ЧУУЛАХ олныг хуралдуулан хэрэг ажлыг зөвлөлдөж хэлэлцэх; **чуулах зөвлөлдөх** х о р ш.; *чуулган чуулах.* ᠴᠤᠯᠠᠬ

ЧУУЛГАН 1. ямар нэгэн хэрэг ажлыг зөвлөлдөхийн тул олноор хуран цугласны нь; *олны чуулган;* 2. зарим албан байгууллагын тогтмол хуралдаан; *Улсын Их Хурлын чуулган; Дээд Зөвлөлийн чуулган; ээлжит чуулган.* ᠴᠤᠯᠠᠭᠠᠨ

ЧУУЛУУЛАХ чуулахын үйлдүүлэх хэв.

ЧУХАГ 1. маш ховор, олдошгүй цөөн; *чухаг эрдэнэ;* 2. чухал хэрэгтэй; *энэ чинь чухаг зүйл байна;* 3. тарчиг ховор; *чухаг жил.*

ЧУХАГДАХ хэтэрхий чухаг болох, ховордох.

ЧУХАГЧЛАХ чухаг болгож үзэх.

ЧУХАЛ маш эрхэм, маш хэрэгтэй; *хамгийн чухал; ховор чухал; онц чухал; чухал эм; чухал эд; чухал мэрэгжлийн хүн; чухал хэрэгцээтэй юм; чухал асуудал; чухал мэдээ; чухал санал; чухал шийдвэр; чухал арга хэмжээ.*

ЧУХАЛЧЛАГДАХ чухалчлахын үйлдэгдэх хэв.

ЧУХАЛЧЛАХ чухал болгох, чухалд үзэх.

ЧУХАЛЧЛУУЛАХ чухалчлахын үйлдүүлэх хэв.

ЧУХАМ бодьтой, жинхэнэ, ёстой, үнэн; *чухам эзэн; чухам эд; чухам сайн; чухам мөн; чухам үнэн; чухмыг хэлбэл...; чухам тийм;* **чухамдаа** (үнэндээ, чанартаа).

ЧУХАМЛАХ 1. жинхэлэх; 2. магадыг олох; 3. чин үнэнээ хэлэх.

ЧУХАМЛУУЛАХ чухамлахын үйлдүүлэх хэв.

ЧУХАМХҮҮ чин үнэнхүү.

ЧҮДЭНЗ ноцоолго, зуруул; *нэг багц чүдэнз; толгой зүдэнз;* **чүдэнз зурах** (чүдэнзийг асаахаар хавирах); **чүдэнзний толгой** (чүдэнзний ноцоох үзүүр): **чүдэнзний зуруул** (чүдэнзийг зурж ноцоох зүйл); **чүдэнзний хайрцаг** (чүдэнз агуулах жижиг хайрцаг); **чүдэнзний мод** (чүдэнзний иш мод); **чүдэнзний фабрик** (чүдэнз үйлдвэрлэх үйлдвэр).

ЧҮҮ малыг явуулах ба босгохоор шавдахад хэрэглэх аялга; *чүү, чүү чүү!*

ЧҮЧЭЭ: ачаа чүчээ ачаа юм.

ЧЭЭГ: чээг чээг зарим малыг хоргоох тогтооход хэрэглэх аялга.

ЧЭЭГЛЭХ малыг чээг чээг гэж хоргоох, тогтоох; *ямаа чээглэх; адуу чээглэх.*

ЧЯС: чяс хийх 1. зарим нэгэн амьтны сочмог чанга дуугарах; *чяс хийтэл орилох;* 2. ямар нэгэн шалтгаанаар бие махбодын энд тэнд гэнт сочтол өвдөх; *хурууны өндөг чяс хийх.*

Ш

Ш Ш үсэг Ш авиа.

ШАА I торолж сийрэгхэн нэхсэн бараа; *хялгасан шаа; гуулин шаа; мяндсан шаа; шаа зондон; шаа магнаг;* 2. тор; *шигшүүрийн шаа.*

ШАА II 1. тэмээний хоёр суганы завсар тогтсон эвэр бэрсүү; *шаатай тэмээ эдэлгээнд тохирохгүй;* 2. морь малын тавагтаа хүртэл тэгшхэн элэгдсэн туурай; *шаатай морь; холын уналгад бүү уна.*

ШАА III я р и а шаг.

ШАА IV шагаа яс.

ШААВАЙ идэр сайхан, ганган, дэгжин; **ганган шаавай** х о р ш.; *шаавай нуруутай хүн; шаавай залуу.*

ШААВАР шаахай.

ШААГДАХ 1. шаахын үйлдэгдэх хэв, 2. үйл хэрэгт тулгагдах; *ам шаагдах; хэрэг шаагдах;* 3. хүнддэх; *ачаа шаагдах; шаагдах ачаа, холын аянд тохиромжгүй.*

ШААГИУЛАХ шаагихын үйлдүүлэх хэв.

ШААГИХ I үйл ажилд хөнгөн гавшгай, сэргэлэн золбоотой хөдлөх, аашлах; **шуугих шаагих** х о р ш.; *шаагисан гавшгай ажилчин; шаагисан сайхан явдалтай морь; шажигнасан залуучууд, ажлаа шаагиулан хийцгээж байгаа нь бахдалтай.*

ШААГИХ II салхи салхилан гэнт үүлшиж, хур бороо ширүүн орох; *бороо шаагих; шаагиж орох; үүл шаагих.*

ШААГУУ у р г а м а л модны иш цэх бөгөөд гүйлс мэт, жимсний өнгө байдал аламрадтай адил, амт хурц хүчтэйхэн нэгэн зүйл жимс.

ШААЗ I чанар муутай; *шааз алт; шааз мөнгө.*

ШААЗ II өрлөн сумтай буу.

ШААЗАН элс шавар зэргийг боловсруулж хийсэн эд хэрэглэл; *шаазан аяга; шаазан тавag; шаазан сав; нарийн шаазан; бүдүүн шаазан; шаазан өвгөн; шаазангийн нарийн шавар; шаазангийн үйлдвэр;* **гангар шаазан** (маш нарийн шаазан).

ШААЗГАЙ а м ь т а н хэрээтэй адил болоод бие жигүүр дундуур цагаан, сүүл урт, шагшин дуугардаг нэг зүйл шувуу, биеийн урт нь 45—48 сантиметр, жимсгэнэ ба үр тариа, хорхой шавьж идэнэ, модонд үүр засна, төрөл зүйл олон; *шаазгайн үүр; шаазгайн сүүл; шарын өндөр ууланд шаазгай шувуу шагширна* (дуу).

ШААЗГАЙЛИГ: шаазгайлиг хөхөө а м ь т а н уулын шаазгайтай адил болоод жижиг хэн нэгэн зүйл шувуу.

ШААЛАЙЛГАХ шаалайхын үйлдүүлэх хэв.

ШААЛАЙХ элбэгдэх; *өмд шаалайх; дээл шаалайх.*

ШААЛАХ I юмны гадна өнгө этгээдийг ховхлон хуулж авах; **хуулах шаалах** х о р ш.; *модны дурс холтсыг шаалах; дээл хувцасны гадар өнгийг шаалах.*

ШААЛАХ II я р и а шаглах.

ШААЛУУЛАХ шаалахын үйлдүүлэх хэв.

ШААН: шаан паан үл ялих яриан маргаан: *шаан паан хийх хэрэггүй, шалавхан түргэн ажлаа хий!*

ШААНТ дунд чөмөгний дор залгалдан орших чөмөг яс, шагайт чөмөг ч гэдэг; *шаант чөмөг.*

ШААНТАГ юмны зай завсар ба хөндлөн чагтлах юманд чангалж шаах мод; *тэрэгний шаантаг; сүхний шаантаг.*

ШААНТАГДАХ 1. шаантаг шаах, шаантаглах; 2. ш и л ж с э н бусдыг сүрдүүлэн мундагдах.

ШААНТАГДУУЛАХ шаантагдахын үйлдүүлэх хэв.

ШААНТАГЛАХ шаантагдах, шаантагтай болгох.

ШААНТАГЛУУЛАХ шаантаглахын үйлдүүлэх хэв.

ШААР 1. шим шүлтгүй, хэрэгцээгүй үлдэгдэл юм, шараг ч гэдэг; **шаар шавхруу** х о р ш.; *цайны шаар;* 2. ш и л ж с э н гологдмол, ялгагдмал муу юм; *малын шаар; амьтны шаар хүний шаар; эдийн шаар.*

ШААРАГ 1. үрийн зүйлээс тосыг ялгаж аваад үлсэн цөв; 2. пиво дарс зэргийн бажмаг цөв; 3. үйлдвэрээс хэрэггүй болж үлдсэн хог хаягдал; 4. цайны хашин үлдэгдэл.

ШААРДАГДАХ шаардахын үйлдэгдэх хэв. шаардагдах чухал ажлыг **төлөвдөх.**

ШААРДАЛ шаардлага.

ШААРДАХ 1. үйл ажлыг гүйцэтгэх бүтээхэд зайлшгүй холбогдох нөхцөл бололцоог нээх, шаардлага тавих; **шавдах шаардах, нэхэх шаардах** х о р ш.; *хөрөнгөтөн оронд ажилчид ажлын хөлсийг нэмэгдүүлэхийг байн байн шаардаж байна; нөхцөл боломжоор хангахыг шаардах;* 2. ажлыг гүйцэтгүүлэхээр шаардлага тавих; *төлөвлөгөөт ажлыг биелүүлэх талаар шаардах; ажил шаардахад дургүйцэх хүн байж болохгүй.*

ШААРДЛАГА шавдаж шаардах үйлийн нэр; *шаардлага сайтай; шаардлага муутай; ажлын шаардлага; хэрэгцээний шаардлага; өнөөгийн шаардлага; цаг үеийн шаардлага; эдийн засгийн шаардлага.*

ШААРДУУЛАХ 1. шаардахын үйлдүүлэх хэв; 2. шаардагдах.

ШААРЛАГДАХ шаарлахын үйлдэгдэх хэв.

ШААРЛАХ 1. юмны шаары нь ялгаж арилгах; *цай шаарлах;* 2. олон буюу их юмны дотроос голж муугий нь заазлан ялгах; *мал шаарлах.*

ШААРЛУУЛАХ 1. шаарлахын үйлдүүлэх хэв; 2. шаарлагдах, гологдож ялгагдах.

ШААТАХ морь малд шаа өвчин тохиох.

ШААХ 1. юмыг юманд шигтгэн нэвтрүүлж оруулахаар давтан цохих; *гадас шаах;* 2. шувуу хушуугаараа юм цохих тонших; *бүргэд шаах;* 3. зангидсан гараар дэлдэх; *гараар шаах;* 4. зарим оромжийг барих, босгох; *майхан шаах; асар шаах;* 5. найдаж тулгах; *лаахай шаах; ам шаах;* 6. ойртох, тулах; *давааид шааж буувал өглөө эрт давахад хялбар.*

ШААХАЙ I хөлд өмсөх түрийгүй гутал; *зөөлөн шаахай; эмэгтэй хүний шаахай; өрөвсөн шаахай.*

ШААХАЙ II х у у ч и р с а н урьдын цагт ял хэрэг халдсан хүний шанаа дээр жанчиж байсан эрүүгийн хэрэгсэл; **шаахай банз** х о р ш..

ШААХАЙДАХ х у у ч и р с а н шаахайгаар жанчих.

ШАВ I 1. харвалга, буудлагын бай; **бай шав** х о р ш.; *шав буудах; буудлагын шав;* 2. гэр орон барьж байгуулах газрыг урьдчилан үзэж тавьсан тэмдэг, шавга ч гэдэг; **шав тэмдэг** х о р ш.; *шав босгох; шав тавих.*

ШАВ II цохисон дэлдсэнээс шад хийж гарах дуу чимээ; *ташуурын дуу шав хийв; савааны дуу шав хийв;* **шав хийх** (цохисон дэлдсэнээс шад хийж чимээ гарах; *шав хийтэл гуядах, ороолгох);* **шав шав хийх** (шав хийсэн чимээ үргэлжлэн гарах.

ШАВ III: **шав шар** маш шар өнгө; шав шар үстэй хүн.

ШАВ IV: **шав хийсэн** 1. гавшгай, гялалзуур; *шав хийсэн хүн;* 2. аливаа юмыг магтах зэрэгт хэрэглэх үг; *шав хийсэн эмээл байна даа.*

ШАВААРАЛДАХ шаваарахын үйлдэлдэх хэв; *олон хүн шаваараллан зогсож байв.*

ШАВААРАЛДУУЛАХ шаваараллахын үйлдүүлэх хэв.

ШАВААРАХ овоорох, цугларах, бөөгнөрөх; *үхрийн баасан дээр ялаа шаваарах .*

ШАВААРУУЛАХ шаваарахын үйлдүүлэх хэв.

ШАВААС шавсан юм; *байшингийн шаваас; аргалын шаваас.*

ШАВААСЛАХ шаваас хийх, шаваастай болгох, шавах; *овоолсон аргалаа шавааслах; хашааны завсрыг шавааслах.*

ШАВААСЛУУЛАХ шаваасласхын үйлдүүлэх хэв.

ШАВАГ у р г а м а л модорхог бутархаг ургамал, зүйл ялгал олон; *шар шаваг; хар шаваг; цагаан шаваг.*

ШАВАГДАХ шавахын үйлдэгдэх хэв.

ШАВАЙ малын цусыг амталж, ходоод олгойд нь хийж чанасан хоол; *хонины шавай;* **шавай нь ханах, шавай нь дүүрэх** (бах нь ханах).

ШАВАЛДАХ 1. шавахын үйлдүүлэх хэв; 2. ш и л ж с э н олноороо хуран цугларах.

ШАВАЛДУУЛАХ шавалдахын үйлдүүлэх хэв.

ШАВАН дархан хүний алт мөнгийг цуван татах хэв.

ШАВАНДАХ шаванд цуван татах.

ШАВАР 1. наанги, наалданги шороо; *нарийн шавар; цагаан шавар; шар шавар; шавар зуурах; шавар бялдах; шаварт шигдэх; шавраар шавах;* **шавар болох** (юм шавартай болох); 2. наалданги шороогоор хийсэн, үйлдсэн юм; *шавар зуух; шавар пийшин; шавар байшин; шавар ваар;* 3. намаг, шавхай; **шавар намаг, шавар шавхай** х о р ш.

ШАВАРДАХ 1. шавартай болох, болгох; *гутлаа шавардах; байшин шавардах;* 2. шаварт шигдэх; *машина шавардах;* 3. хэтэрхий шавартай болох; *шавардаад явж болохгүй байв.*

ШАВАРДУУЛАХ 1. шавардахын үйлдүүлэх хэв; 2. шавардагдах.

ШАВАРЛАГ 1. шавар ихтэй; *шаварлаг хөрстэй газар;* 2. шавар байдалтай.

ШАВАРТ шавар бий.

ШАВАРТАЙ шавар бүхий; *шавартай газар; шавартай гутал.*

ШАВАРТАХ шавартай болох, шавар бий болох.

ШАВАРТУУЛАХ шавартахын үйлдүүлэх хэв.

ШАВАРЧ (ИН) шавраар урлах, шавардах ажилд чадамгай хүн.

ШАВАХ I 1. юмыг хучих, бүрхэх, бөглөх; *байшин шавах; шавраар шавах; давирхайгаар шавах; хөхүүлж шавах; баасаар шавах; хувингийн ёроол шавах;* 2. цугларах, бөөгнөрөх, шаваарах; *хүүхэд багачууд шавах.*

ШАВАХ II 1. бөхчүүдийн өрж зогсоод, гараар нүцгэн гуяа алгадах; *бөх шавах; шавж өрж зогсох;* 2. тэмээний хойд хоёр хөлөө алцайж зогсоод, сүүлээрээ биеэ сажлан цохих; *ингэ шавах; буур шавах.*

ШАВГА 1. модон савны завсартсан газрыг бөглөх мод: **шавга савх** х о р ш.; 2. шодоход хэрэглэх савх мод: **шавга татах** (а. шавга модонд нэрсийг бичиж, холиод татаж сугалан авах; б. шодох, сугалах); **шавга орхих** (юмны ээлж хувиар хэнд ногдохыг шавга модонд бичиж татан сугалж ногдуулах); **шавга гүйлгэх** (ээлжилж гүйцэтгэх үүрэг бүхий хүмүүс, ээлж ногдсон хүндээ шавга модыг гардуулан өгөх).

ШАВГАЛАХ өв тоо зохиож шавга орхих, шодох, сугалах.

ШАВГАЛУУЛАХ шавгалахын үйлдүүлэх хэв.

ШАВДАГДАХ 1. шавдахын үйлдэгдэх хэв; 2. усны хүчинд, газар дайрагдаж идэгдэн эвдрэх; *үерийн усанд шавдагдсан газар.*

ШАВДАЛ: шавдал авах гарын бугуй дээр хоёр хуруугаар савж цохихыг.

ШАВДАН: шавдан бат насан хутаг, урт удаан наслахыг бэлэгдэж хэлэх үг; *шавдан бат болтугай!*

ШАВДАХ I гарын бугуй дээр хоёр хуруугаар савж цохих, шавдал авах ч гэдэг,

ШАВДАХ II байн байн шаардах, шамдах, яаруулах; **шаардах шавдах, шалах шавдах шахах шавдах** х о р ш.. ᠰᠠᠭᠤᠳᠠᠬᠤ • ᠰᠠᠭᠤᠳᠠᠭ

ШАВДАХ III харвасан зэвсэг, онох юмыг хальт ялин онох.

ШАВДАХ IV юмыг нүхлэх, цоолох.

ШАВДАХ V юмыг шаванд татах; цувах шавдах, шавж татах.

ШАВДАХ VI усны урсгал, газрыг дайралсаар идэж эвдэх; *шавдаж эвдэх; ус шавдах.*

ШАВДУУ яаруу, шамдуу, шаардлагатай; **яаруу шавдуу, түргэч шавдуу** х о р ш.; *ажилд шавдуу хүн.* ᠰᠠᠭᠤᠳᠠᠭᠴᠢ

ШАВДУУЛАХ 1. шавдахын үйлдүүлэх хэв, шаардуулах, яаруулах; 2. шавдагдах. ᠰᠠᠭᠤᠳᠠᠭᠤᠯᠬᠤ

ШАВИЛАХ I 1. Буддын шашны лам нарын шавь хувцас (номын хувцас)-аа өмсөх; 2. хүрээ хийдэд лам болж суух; *шавилан суух.* ᠰᠠᠭᠤᠯᠬᠤ

ШАВИЛАХ II бусдын юмыг аргаар авч ашиглах, завших.

ШАВИР: шивэр шавир хийх сэм шивэгнэлдэн ярих; *шивэр шавир хийгээд ямар юмаа ярилцаж байгаа юм?* ᠰᠠᠭᠤᠷ

ШАВИРААЧИН бадарчин, гуйлгачин; **бадарчин шавираачин, гуйлгачин шавираачин** х о р ш.. ᠰᠠᠭᠤᠷᠠᠭᠴᠢᠨ

ШАВИРААЧЛАХ бадарчлах, гуйлгачлах. ᠰᠠᠭᠤᠷᠠᠭᠴᠢᠯᠠᠬᠤ

ШАВУУЛАХ 1. шавахын үйлдүүлэх хэв; 2. шавагдах. ᠰᠠᠭᠤᠭᠤᠯᠬᠤ

ШАВХ 1. зуурч удаад наалдаа болсон шавар; **шавар шавх** х о р ш.: 2. шавхай; **шавх нугас** (шонхор нугасны өөр нэр). ᠰᠠᠭᠤᠭ ᠨᠤᠭᠠᠰ

ШАВХАЙ норж нялцайн наалдангир болсон шороо, шавар; *хотны шавхай; гудамжны шавхай.* ᠰᠠᠭᠤᠭᠠᠢ • ᠰᠠᠭᠤᠭᠠᠢ

ШАВХАЙДАХ 1. хэтэрхий шавхай болох; 2. шавхайтай болгох. ᠰᠠᠭᠤᠭᠠᠢᠳᠠᠬᠤ

ШАВХАЙДУУЛАХ шавхайдахын үйлдүүлэх хэв. ᠰᠠᠭᠤᠭᠠᠢᠳᠠᠭᠤᠯᠬᠤ

ШАВХАЙТ шавхай бий. ᠰᠠᠭᠤᠭᠠᠢ ᠪᠢ

ШАВХАЙТАЙ шавхай бүхий; *шавхайтай гудамж; шавхайтай гутал.* ᠰᠠᠭᠤᠭᠠᠢ ᠲᠠᠢ

ШАВХАЙТАХ шавхайтай болох, шавхай тогтох, ᠰᠠᠭᠤᠭᠠᠢᠲᠠᠬᠤ

ШАВХАЙТУУЛАХ шавхайтахын үйлдүүлэх хэв. ᠰᠠᠭᠤᠭᠠᠢᠲᠠᠭᠤᠯᠬᠤ

ШАВХАР худгийн ам орчноор тогтсон шавхай ус; *худгийн шавхар.* ᠰᠠᠭᠤᠭᠠᠷ

ШАВХАРГАХ 1. шавхруулах, шавхрахад хүргүүлэх; 2. шавхрагдах. ᠰᠠᠭᠤᠭᠠᠷᠭᠠᠬᠤ

ШАВХАРТАХ 1. шавхар тогтох; *худгийн ам шавхартах;* 2. дээрээс доош мөс унжиж хөлдөх; *байшингийн дээврийн цас хайлж, доош унжин шавхартах.* ᠰᠠᠭᠤᠭᠠᠷᠲᠠᠬᠤ

ШАВХАХ 1. шингэн юмны үлдэгдлийг дуустал гаргах, авах; *худгийн ус шавхах; тогоотой цай шавхах;* 2. барж дуусгах; *байгаагаа барж шавхах; тариагаа хурааж шавхах; эд хөрөнгийг цөлбөн шавхах; чадлаа шавхах; хүчээ шавхах.* ᠰᠠᠭᠤᠭᠠᠬᠤ

ШАВХДАХ юманд шавх наалдах, шавардах. ᠰᠠᠭᠤᠭᠳᠠᠬᠤ

ШАВХДУУЛАХ шавхдахын үйлдүүлэх хэв, шавардуулах. ᠰᠠᠭᠤᠭᠳᠠᠭᠤᠯᠬᠤ

ШАВХИЙХ 1. сэргэлэн цовоо, хөнгөн гавшгай хөдөлгөөнтэй, авхаалжтай байх, шаг хийх ч гэдэг; *шавхийсэн хүн; шавхийсэн морь;* 2. юмны яс чанар бүсдаасаа илүү дээр болох; *шавхийсэн ястай торго; шавхийсэн модтой эмээл; шавхийсэн тохьтой гэр.* ᠰᠠᠭᠤᠬᠢᠶᠠ

ШАВХРААХ шавхрахад хүргүүлэх; *усы нь шавхраах.* ᠰᠠᠭᠤᠭᠤᠯᠬᠤ

ШАВХРАГА 1. шавхруу, шаар, үлдэгдэл, 2. шавхар; 3. эмэгтэйчүүдээс хүүхэд төрүүлсний дараа гарах юм. ᠰᠠᠭᠤᠭᠤᠷ

ШАВХРАГАДАС 1. шавхрага; 2. шавхарч гарсан юм. ᠰᠠᠭᠤᠭᠤᠷᠭᠠᠳᠠᠰ

ШАВХРАГДАХ шавхрахын үйлдэгдэх хэв. ᠰᠠᠭᠤᠭᠤᠷᠭᠠᠳᠠᠬᠤ

ШАВХРАХ I 1. савны дотоод шингэн зүйлийг хөнтрөн шавхах; *данхаа шавхрах;* 2. норж нэвтэрсэн юмны усыг сэгсрэх мушгих зэргээр гаргах; *усы нь шавхрах хэрэгтэй;* 3. барах дуусгах; *байсныгаа барж, шавхрах ойртож байна.* ᠰᠠᠭᠤᠭᠤᠷᠬᠤ

ШАВХРАХ II жанчигдсан цохигдсоноос болж арьс мах нялтрах; *арьс шавхрах.*

ШАВХРАХ III нарийн юмаар савж цохиж ороолгох; *сураар шавхрах; олсоор шавхрах.*

ШАВХРУУ юмны үлдэгдэл; **шаар шавхруу** х о р ш.; *цайны шавхруу; хоолны шавхруу; гурилын шавхруу; малын шавхруу; шавхруу дээр нь очих.* ᠰᠠᠭᠤᠭᠤᠰᠤ

ШАВХРУУЛАХ 1. шавхрахын үйлдүүлэх хэв; 2. шавхрагдах. ᠰᠠᠭᠤᠭᠤᠷᠭᠤᠯᠬᠤ

ШАВХТАХ шавхтай болох, шавар тогтох, шавхайтах ч гэнэ. ᠰᠠᠭᠤᠭᠲᠠᠬᠤ

ШАВХТУУЛАХ шавхтахын үйлдүүлэх хэв.

ШАВХУУЛАХ шавхахын үйлдүүлэх хэв.

ШАВХУУРДАХ нарийн урт юмаар юмыг ороолгон цохих; *бүсээр шавхуурдах; бургасаар шавхуурдах.*

ШАВХУУРДУУЛАХ 1. шавхуурдахын үйлдүүлэх хэв; 2. шавхуурдагдах.

ШАВШИГДАХ шавшихын үйлдэгдэх хэв.

ШАВШИХ юмны дээрээс нь ус зэрэг шингэн зүйлийг дахин дахин түрхэх, сүрших, асгах зэргээр түгээж норгох; *толгой шавших; хамуутай тэмээг эмээр шавших; шавшиж дэвтээх; бороо шавших; усаар шавших; тосоор шавших.*

ШАВШЛАГА 1. шавших юм; *шавшлага ус;* 2. хөвөн даавуу зэргийг шингэн эмээр шавшин норгож өвчтэй газар нь тавьж эмчлэх арга.

ШАВШРАГА 1. салаагүй модны үзүүр; 2. цохих жанчих саваа торлог, шавшуур ч гэнэ.

ШАВШУУЛАХ 1. шавшихын үйлдүүлэх хэв; 2. шавшигдах.

ШАВШУУР 1. шавшдаг юм; 2. саваа, торлог, шавшрага ч гэнэ.

ШАВШУУРДАХ арьс шир зэрэгт тогтсон тоосыг шавшуураар цохиж арилгах, саваадах.

ШАВШУУРДУУЛАХ шавшуурдахын үйлдүүлэх хэв.

ШАВЬ I бусдаар юм заалгаж, сурч байгаа хүн, сурагч; **шавь сурагч** х о р ш.; *багшид шавь орох; шавь болох; нэрт эрдэмтний шавь сайн байх ёстой; багш шавийн барилдлага.*

ШАВЬ II 1. х у у ч и р с а н шар феодалын харьяат захиргаанд захирагдаж байсан албат хүмүүс; *Богдын шавь; хутагтын шавь; гэгээний шавь; шавийн отог; шавийн албат; Шавийн яам;* 2. х у у ч и р с а н сүм хийдэд шавилан суугч лам нар; **лам шавь** х о р ш.; *лам нар, шавь нарыгаа ихэд зарцалдаг байв.*

ШАВЬЖ 1. үет хөлт, сээргүй амьтны аймгийн ерөнхий нэр, зүйл ялгал маш олон, амьтан ургамлаар амьдрана; **хорхой шавьж** х о р ш.: 2. жаран хөлт; **шавьжийн судлал** (амьтны аймгийн судлал дотор тусгайлан шавьжийн зүйлийг эрхлэн судлах ухаан); **шавьжийн судлалч** (шавьжийн судлалд мэргэжсэн хүн).

ШАГ I дуу чимээ дууриах аялга үг; **шаг шуг, шаг шиг** х о р ш.; **шаг хийх** (нэг удаа шаг гэсэн чимээ гарах); **шаг шаг хийх** (шаг гэсэн чимээ үргэлжлэн гарах).

ШАГ II шатраар наадахад бэрс, тэрэг, мориор шаглахад хэлэх аялга үг, шалах, шаглах; *бэрсээр шаг гэж сүртэйгээ шалахад тэргээр хэрэлдүүлэн хаав.*

ШАГ III: **шаг хийх** сайн; *шаг хийсэн хүн; шаг хийсэн гэр; шаг хийсэн сандал; шаг хийсэн зураач; шаг хийсэн дархан.*

ШАГ IV хоол ундны өчүүхэн үлдэц, шавхруу.

ШАГАА 1. амьтны шаант ясны нарийн үзүүрт орших жижиг яс; 2. шагааны орших орчин газар, зарим газар шаа ч гэнэ; **шагаа орхих** (а. шагааг атгаж газар хаях; б. шагаа нясалж наадах); **шагаа няслах** (хоёр этгээд ээлжлэн шагааг орхиж, ижил ижлий нь няслан харваж, оносныг авч наадах, бөг цэг няслах ч гэнэ): **шагаа харвах** (олон хүн нийлж, шагааг өрж сах сумаар харван унагааж талцан наадах); **шагаа таалцах** (хоёр этгээд адил тооны шагааг барьж тус тусын тасалж атгасан шагаагийн тоог нийлүүлэн бодож оноож хэлсэн нь нөгөө этгээдийнхийг авч наадах); **шагаа өлгөцөх** (шагаа шүүрэх); **шагаа шүүрэх, шагаа авах** (шагаацах, шагалцах).

ШАГААВАР буу буудахад зориулж хэрмийн хананд хийсэн нүх.

ШАГААГУУР 1. шагааж харахад зориулсан ямар нэгэн нүх сув; 2. шагааж харах хэрэгсэл.

ШАГААЛГАХ I шагаахад хүрүүлэх.

ШАГААЛГАХ II юмны завсраар өөр өнгө цухуйлгах; *алт шагаалгах, улаан өнгө шагаалгах.*

ШАГААХ шагайх; *ор гэхэд шагаах, ид гэхэд долоох;* 2. цухуйх; *уулын толгойгоор нар шагаах; тооноор гэрэл шагааж байна;* 3. өө сэв эрэлхийлэх; *ул шагаах.*

ШАГААЦАХ тараасан шагааг дээш хаясан сум шүүргийг бууж ирэхийн урьд хаман атгаж, сум шүүргийг тосон авч наадах тоглоом, шагалцах ч гэдэг.

ШАГААЧИН шагаагаар наадах олон хүн.

ШАГАЙ шагаа.

ШАГАЙВАР шагаавар.

ШАГАЙВЧ: шагайвч гутал богино түрийтэй нэг зүйл гутал.

ШАГАЙГУУР шагаагуур.

ШАГАЙХ 1. үүд хаалга, нүх цоорхой мэтээр цухалзан харах; *цонхоор шагайх; гэрийн цоорхойгоор шагайх;* 2. юм рүү хараа тааруулан чиглүүлэх; шагаах ч гэнэ; *буу шагайх; ном шагайх.*

ШАГАЙЧИН шагаачин.

ШАГАЛГАР өндөр биш, намхан.

ШАГАЛЦАХ шагаа өлгөцөж наадах, шагаацах.

ШАГЛААС шаглаж оёсон оёдол.

ШАГЛАХ I юмыг хөшиж хатгасан газраар дахин эргүүлж нягт үргэлж утас үзэгдүүлэн оёх.

ШАГЛАХ II шатарцахад морь; тэрэг, бэрсээр шалах.

ШАГНАГАР амьтны хамар суунги гандгары нь; *шагнагар хамартай хав.*

ШАГНАГДАХ шагнахын үйлдэгдэх хэв.

ШАГНАЙЛГАХ шагнайхад хүрүүлэх, шантайлгах; *хамраа шагнайлгах.*

ШАГНАЙХ шагнагар болох, шантайх; *хамар нь шагнайх.*

ШАГНАЛ шагнаж олгох юм; *төрийн шагнал; мөнгөн шагнал; зохиолын шагнал.*

ШАГНАЛТ шагнал бүхий; *төрийн шагналт; академийн шагналт.*

ШАГНАХ онц бүтээл зүтгэл гаргаж гавьяа байгуулагчдад олгох хөхүүлэл, урамшлын зүйл; *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хөдөлмөрийн баатар цол шагнах; мөнгө эд шагнах; одон тэмдэг шагнах; үнэмлэхээр шагнах.*

ШАГНУУЛАХ 1. шагнахын үйлдүүлэх хэв; 2. шагнагдах.

ШАГТЬ 1. сэхээ самбаа, бэх бат, ид хав; 2. илд.

ШАГШААВАД шашин гажуу буруу үйл явдлыг цээрлэж, сэтгэлийг боож барих санаа, сахилга.

ШАГШИГДАХ шагшихын үйлдэгдэх хэв.

ШАГШИЛЦАХ шагшихын үйлдэлцэх хэв.

ШАГШИХ 1. юмыг гайхан магтаж хэлэлцэх буюу шоодворлон муушаах зэргээр олноор дүрхрэн хэлэлцэх; **шагших шуугих** хорш.; *шагшин магтах; шагшин хэлэлцэх;* 2. шаазгай зэрэг амьтны шаг шаг дуугарцгаах; *шаазгай шагших;* 3. шагшрах.

ШАГШРАХ зэмлэн буруушааж хэлэлцэх, гаслах, ам танших.

ШАГШРУУЛАХ 1. шагшрахын үйлдүүлэх хэв; 2. шагшрагдах.

ШАГШУУЛАХ 1. шагшихын үйлдүүлэх хэв; 2. шагшигдах.

ШАГШУУРГА 1. өвс ургамлын толгойд тогтсон ус; цан; *өвсний толгойд шагшуурга тогтжээ;* 2. нуур голын дотор ургасан зэгс зэрэг ургамлын бөөн хэсэг; **шагшуурга бялзуухай** амьтан (хуй шаазгайгаас бяцхан, хоёр урт сүүлтэй, хулс ба үет цагаанд үүр засдаг нэг зүйл шувуу).

ШАШУУРГАЛАХ шагшуурга бий болох, шагшуурга тогтох.

ШАГШУУРГАТАХ шагшуургатай болох.

ШАГШЧИХ байн байн шагшрах, олноороо шагших.

ШАД I шүлгийн нэг мөр; *дөрвөн шад шүлэг.*

ШАД II: **шад цэцэг** ургамал удамбар цэцэгтэй адилхан, үнэр анхилам сайхан нэгэн зүйл ургамал.

ШАД III: **шад хийх** юмнаас тас гэсэн чимээ гарах: **шад шад хийх** (юмнаас тас тас хийх чимээ гарах, шад шуд хийх ч гэнэ).

ШАДАР 1. ойр, дөт; **ойр шадар** хорш.; *шадар айл; шадар тосгон; хотод шадар оршдог; шадар газар;* 2. дотно, итгэлтэй; *шадар нөхөр; шадар хүн;* **шадар сайд** (төрийн тэргүүнд бараа болох сайд төрийн сайд).

ШАДАРДАХ юманд ойр болох.

ШАДАРДУУЛАХ шадардахын үйлдүүлэх хэв.

ШАДАРЛАЛ шадарлах үйлийн нэр.

ШАДАРЛАХ ойр болох ба болгох, юмны ойртох.

ШАДАРЛУУЛАХ шадарлахын үйлдүүлэх хэв.

ШАЖИГНАХ юмны хугарах няцрах, хөдлөх эвдрэх зэрэгт шар шар чимээ гарах; *цас шажигнах; модны навч шажигнах; цаас шажигнах; ор шажигнан хөдлөх.*

ШАЖИГНУУЛАХ шажигнахын үйлдүүлэх хэв.

ШАЖИН я р и а шашин.

ШАЖЛАХ хорих, цаазлах.

ШАЖЛУУЛАХ шажлахын үйлдүүлэх хэв.

ШАЗ улбарч ялзартал чанасан мах; *толгойн шаз; шаз мах; шаз чанах.*

ШАЗАЙЛГАХ шазайхын үйлдүүлэх хэв.

ШАЗАЙХ 1. ярзайх; *шүд шазайх; дээвэр шазайх;* 2. хэвцэглэх, их зан гаргах, ярдаглах.

ШАЗАЛЗАХ 1. шазгар юмны байн байн хөдлөх; 2. юмны буцлах ойртож хөдлөх.

ШАЗАЛЗУУЛАХ шазалзахын үйлдүүлэх хэв.

ШАЗГАНАХ шазгар юмны шазга шазга хөдлөх.

ШАЗГАНУУЛАХ шазганахын үйлдүүлэх хэв.

ШАЗГАР 1. хэвцгий, ярдаг; *шазгар хүүхэд; шазгар зан;* 2. ярзгар; *шазгар уруул.*

ШАЗЛАХ 1. шаз болгох; *мах шазлах;* 2. язлах, нялтлах; 3. түлэх; *халуун усанд гараа шазалж орхив.*

ШАЗЛУУЛАХ шазлахын үйлдүүлэх хэв.

ШАЗРАХ 1. ялзрах, шаз болох; 2. язрах, хэгэрэх, нялтрах; 3. түлэгдэх.

ШАЗРУУДАХ хэтэрхий шазруун болох.

ШАЗРУУЛАХ шазрахын үйлдүүлэх хэв.

ШАЗРУУН омолгон, долгин зан байдалтай; *яасан шазруун залуу вэ?*

ШАЗУУР хөмхий, шүд; **шазуур зуух** (а. хөмхий б. өшөө хонзон хадгалж явах).

ШАЗУУРЛАХ хөмхий зуух, шүд зуух.

ШАЛ I байшин барилга, гэр орон зэргийн тоосго чулуу, мод зэргээр хийсэн дэвсгэр; *гэрийн шал; байшингийн шал; шал тавих.*

ШАЛ II гутлын хавчаар хийх, хэнгэрэг ширлэхэд хэрэглэх нэгэн зүйл илэг.

ШАЛ III шингэн нялцгай юмыг цохих дэлдэхэд гарах чимээ; **шал хийх** (а. юмнаас цал гэсэн чимээ түр гарах; б. бие сулдасхийж ядрах; *бие шал хийх);* **шал шал хийх** (а. шал гэсэн чимээ байн байн гарах; б. дэмий олон уг ярих; *битгий шал шал хийгээд байгаарай);* **шал шүл хийх** (сая хэлэнд орж байгаа буюу бага хүүхдийн учир нь мэдэгдэхгүй уг ярих); **шал бал** (хүний салан задгай буюу уг тодорхойгүй бүдүүлэг байдалтайгий нь; *шал бал хүн шүү);* **шал пал хийх** (а. зарим хүмүүсийн учир нь үл мэдэгдэхээр ярих хэлэлцэх, шалаан палаан хийх ч гэнэ: б. нохойн шингэн хоол идэхэд шал шал хийх чимээ гарах; в. ус шалбаагтай газар амьтны явах зэрэгт шал цал хийх чимээ гарах).

ШАЛ IV бүр, огт; *шал тэнэг; шал дэмий; шал худал.*

ШАЛАВ хурдан, түргэн; *шалав яваарай; шалав ирээрэй.*

ШАЛАВЛАХ маш хурдлах, түргэлэх, бушуулах.

ШАЛАВЛУУЛАХ шалавлахын үйлдүүлэх хэв, түргэлүүлэх, хурдлуулах, бушуулуулах.

ШАЛАВХАН маш шалав, хурдхан, түргэхэн; *шалавхан ирээрэй.*

ШАЛАВЧ шалыг хааж дэвсэх дэвсгэр; *гэрийн шалавч; шалавч ширдэг; шалавч дэвсгэр.*

ШАЛАГНАХ 1. тэрэг чирэх малд шалан торгох; 2. зарим юмны унжиж хунирч шалгар болох; *гэрийн бүрээс шалагнах; буслуур шалагнах; өмд шалагнах.*

ШАЛАГНУУЛАХ шалагнахын үйлдүүлэх хэв.

ШАЛАЙ I уруу суулгах өвчин хүрсэн хүний баасны хамт гарах залхаг нус мэт зүйл, элхдэс, салиа ч гэнэ; *шалайгаар суулгах.*

ШАЛАЙ II: **шалай балай** хэрэггүй, жигшмээр, салан задгай; *шалай балай яриа; шалай балай зан.*

ШАЛАЙЛГАХ шалайхад хүргүүлэх.

ШАЛАЙХ шалгар байдал гаргах, шалгар болох; *бие шалайх; өмд шалайх; ажил шалайх.*

ШАЛАМ я р и а шалав, түргэн.

ШАЛАМГАЙ үйл ажилд түргэн завдамхай, шалмаг; *шаламгай ажилладаг ажилчин.*

ШАЛАМГАЙЛАХ үйл хэрэгт чармайж, хурдлан завдаж ажиллах; *ажлаа шаламгайлахгүй бол, цагтаа багтахгүй болно шүү.*

ШАЛАМГАЙЛУУЛАХ шаламгайлахын үйлдүүлэх хэв.

ШАЛАМТГАЙ шаламхай.

ШАЛАМХАЙ дэндүү шалж шаргаадаг, шаламтгай; *шаламхай нь болдоггүй хүн.*

ШАЛАН I үхрийн омрууны дагуу дахь сул арьс.

ШАЛАН II 1. тэрэг чирэх малын гуяны дагуу татаж, тэрэгний арлын гуянаас торгох оосор; 2. тэрэгний буулганд уяж, малын гуянд торгох оосор; 3. элжиг луусны гуянд худраганы адил торгох мод; **шалан оосор** (элжиг луусны шалан модны дундаас уяж гуяны хоорондуур оломд торгох оосор).

ШАЛАН III: **шалан палан хийх** хэрэггүй дэмий яриа дэлгэхийг шоодон өгүүлэхэд хэрэглэх үг.

ШАЛАННАХ шалагнах.

ШАЛАНТ бордож таргалуулсан эр үхэр.

ШАЛАННУУЛАХ шаланнахын үйлдүүлэх хэв, шалагнуулах.

ШАЛАР: шалар шалар хийх 1. хүн амьтны идэх уухад баахан шалиа байдалтай болох; 2. хүний явах хөдлөхөд алгуур назгай байдал гаргах.

ШАЛАРГАХ хүний өмссөн хувцас нь элбэгдэж үзэмж зохимжгүй болох; *шаларгасан хачин хүн харагдав.*

ШАЛАХ I шаргаах, шалгаах, шаардах; **шалах шаргаах, шалгаах шалах, шаардах шалах** х о р ш.; *асууж шалах; гуйж шалах; нэхэж шалах.*

ШАЛАХ II шатарцаж наадахад бэрс, морь, тэргээр эсэргүүцлийн нөөныг зайлж нүүхийг шаардах, шаглах ч гэдэг.

ШАЛБАА 1. бага сага тунасан ус; 2. шалбааг.

ШАЛБААГ намаг, шавар, шавхай; **шавар шалбааг, намаг шалбааг** х о р ш.; *шалбаагтай газар.*

ШАЛБАЙХ 1. шалбааг болох; *цас хайлж шалбайх;* 2. хөлс, усанд норж нэвтрэх; *бороонд шалбайх;* 3. шалайх, сулдасхийх; *биеэ шалбайх.*

ШАЛБАЛАХ шалбарахад хүргүүлэх, шалбаруулах.

ШАЛБАЛЗАХ үйл ажилд шаламгайлан хөдлөх, түргэлэх, хурдлах, бушуулах.

ШАЛБАЛЗУУЛАХ шалбалзахын үйлдүүлэх хэв, түргэлүүлэх, хурдлуулах.

ШАЛБАЛУУЛАХ шалбалахын үйлдүүлэх хэв.

ШАЛБАР 1. ус гатлахад өмсөх, түүхий арьс ширэн тулам гутал; 2. түүхий арьсаар хөлд тохируулан хатааж үдээслэн өдөж өмсөх гутал.

ШАЛБАРАХ 1. мах арьс баахан хагарах, нялтрах; *арьс шалбарах;* 2. эд юмны хальс будаг зэргийн өнгөнхөн холтрох, ховхрох; *будаг нь шалбарах;* 3. юмны чанагдаж ялзрах, нялтрах, шалзрах; *шалбартал чанах.*

ШАЛБАРУУЛАХ шалбарахын үйлдүүлэх хэв.

ШАЛБАРХАЙ шалбарсан газар; *шарх биш шалбархай.*

ШАЛБАЧИХ хэсэг хэсэг буюу олон газар шалбаруулах.

ШАЛБАЧУУЛАХ шалбачихын үйлдүүлэх хэв.

ШАЛБИГАНАХ шалбигар юмны шалбига шалбига хөдлөх.

ШАЛБИГАР шалмигар, чалчгар, нимгэн байдалтай; *шалбигар малгай; шалбигар царайтай; хүч таргаар шалбигар юм.*

ШАЛБИЙЛГАХ шалбийхад хүргүүлэх.

ШАЛБИЙХ 1. усанд юм хум норох, шалбих ч гэнэ; *усанд шалбийх; бороонд шалбийх; шалбийтлаа норох;* 2. шалбигар болж хэлбэр дүрсээ алдах.

ШАЛБИЛЗАХ шалбигар юмны шалбис шалбис хөдлөх.

ШАЛБИХ хур бороо, хөлс зэрэгт хувцас хунар нэвт норох, шалбийх ч гэдэг.

ШАЛГААГДАХ шалгаахын үйлдэгдэх хэв, байцаагдах.

ШАЛГААЛГАХ 1. шалгаахад хүргүүлэх; 2. шалгаагдах.

ШАЛГААХ шалах, шаргаах; **асуух шалгаах, гуйх шалгаах, шалах шалгаах, хоргоох шалгаах** х о р ш..

ШАЛГАДАГ сонгомол юм, шалгагдсан юм; *шалгадаг арга; шалгадаг ухаан.*

ШАЛГАЛГА шалгах үйлийн нэр.

ШАЛГАЛТ 1. зөв буруу эсэхийг шалгахын нь; *ажлын гүйцэтгэлийн шалгалт; санхүүгийн шалгалт;* 2. үзсэн сурсныг шалгахын нь; *орос хэлний шалгалт; жанжны шалгалт;* **улсын шалгалт** (сургуулийн төгсгөлтийн шалгалт); 3. сорилт.

ШАЛГАМАЛ сонгож шалган авсан юм; *шалгамал мал.*

ШАЛГАР 1. залхуу назгай буюу биеийн байдал яданги дорой; *шалгар биетэй хүн;* 2. юмны сул элбэгийн байдал; *шалгар өмд; шалгар турийтэй гутал.*

ШАЛГАРАГДАХ , шалгарахын үйлдэгдэх хэв.

ШАЛГАРАХ юмны дотроос шалгагдаж илүү сайнд тооцогдох; *ажлаар шалгарах; хурдаар шалгарах; чадлаараа шалгарах; эрдмээр шалгарах; уралдаан тэмцээнд шалгарах.*

ШАЛГАРУУЛАХ шалгарахын үйлдүүлэх хэв .

ШАЛГАХ 1. үйл ажлын явц чанар, түүний зөв бурууг хянан магадлаж үзэх; *ажлын биелэлтийг шалгах; данс тайланг шалгах; сурлага чадварыг шалгах; хянаж шалгах; харьцуулан шалгах;* 2. үзэж сурсан зүйлийн сайн мууг магадлах; *амаар шалгах; бичгээр шалгах;* 3. шинэ зүйлийг туршиж сорин үзэх; *машиныг шинэ мотор шалгах; бууны тусгалыг шалгах.*

ШАЛГУУЛАХ 1. шалгахын үйлдүүлэх хэв; *монголын түүхээр шалгуулах;* 2. шалгагдах.

ШАЛДАГНАХ шалдан болгох, нүцгэлэх.

ШАЛДАГНУУЛАХ шалдагнахын үйлдүүлэх хэв.

ШАЛДАН 1. нүцгэн буюу бөгсдөө өмссөн хувцас үгүйгий нь; *ам бардам, гуя шалдан амьтан шив даа;* 2. хонь малын үсгүй нүцгэний нь; **нүцгэн шалдан** х о р ш.; 3. зарим юмны бүрхүүлгүйгий нь; *шалдан гэр;* **шалдан газар** (ургамалгүй газар).

ШАЛДАХ I байшин барилга зэрэгт шал хийх, цардах, шаллах ч гэдэг; **шалдсан зам** (чулуу туйпуу, мод зэргээр засч хийсэн зам).

ШАЛДАХ II газардах, ганцаардах, доройтох.

ШАЛДЛАХ шалдан болгох, шалдруулах, нүцгэлэх.

ШАЛДЛУУЛАХ 1. шалдлахын үйлдүүлэх хэв; 2. шалдлагдах, нүцгэлэгдэх.

ШАЛДРАХ шалдан болох, нүцгэрэх.

ШАЛДРУУЛАХ шалдрахын үйлдүүлэх хэв.

ШАЛДЧИХ байн байн шалдлах, олныг шалдлах.

ШАЛДЧУУЛАХ шалдчихын үйлдүүлэх хэв.

ШАЛЗ (АН) I а м ь т а н үет хөлтний багийн шимэгч хорхой, хонь малын үсэнд шигдэн орж цусыг шимнэ; **шалзан хадаас** (нимгэн тавтай жижиг төмөр хадаас, шалзан шивээ ч гэдэг).

ШАЛЗ II шаз.

ШАЛЗЛАХ шалзруулах, шалз болгох; *толгой шийр шалзлах; мах шалзлах; ногоо шалзлах.*

ШАЛЗЛУУЛАХ шалзлахын үйлдүүлэх хэв.

ШАЛЗРАХ шалз болох, нялтрах, ялзрах.

ШАЛЗРУУЛАХ шалзрахын үйлдүүлэх хэв.

ШАЛИА 1. хоол унд буюу эд юманд асар дур шуналтай биш, хангалуун байдалтайгий нь; *шалиа хүүхэд; шалиа хурга;* 2. хүний хөгширч дойтон, байн байн ташаарч хэлэлцэх болсны нь; **солио шалиа** х о р ш..

ШАЛИАГҮЙ ялиагүй, ялигүй, шалигүй ч гэдэг.

ШАЛИАРАХ идэх уух ба олох авахад дур шунал ханасан мэт байдалтай болох.

ШАЛИАТАХ 1. хүний хөгширч дойтон байн байн ташаарч хэлэлцэх болох; 2. шалиарах, шалиа байдал гаргах.

ШАЛИГ аалигүй, савсаг, самуун, завхай; **шалиг самуун, шалиг савсаг** х о р ш.; *шалиг зан; шалиг явдал; шалиг самуун яваагүй бол, сайнаас ягаад салах вэ* (дуу).

ШАЛИГДАХ I шамшигдах, үрэгдэх; *ашиггүй ажил хийвэл эд хөрөнгө шалигдахаас өөр юу болох вэ.*

ШАЛИГДАХ II хэтэрхий шалиг болох.

ШАЛИГЛАХ шалиг зан байдал гаргах; *дэмий шалиглах хэрэггүй.*

ШАЛИГҮЙ шалиагүй, ялигүй, ялимгүй, ялихгүй; *шалигүй юмны хойноос хөөцөлдөөд яах вэ дээ.*

ШАЛИМТГАЙ шалимхай.

ШАЛИМХАЙ 1. үрэмхий, үрэмтгий; 2. шалиа зан байдалтай.

ШАЛИУЛАХ шалихын үйлдүүлэх хэв, үрүүлэх; **үрүүлэх шалиулах** х о р ш..

ШАЛИХ I 1. нялх хүүхдийн сая хоолонд орж бага сага юм гоочлох болох; *манай хүүхэд одоогоос хоол шалих болж байна;*

2. юманд хангалуун байдалтай болох, юмыг дэмий сүйтгэн үрэгдүүлэх, шалиа болох.

ШАЛИХ II хүний хэлэлцэхдээ ташааран ярих болох; **шалих солих** х о р ш..

ШАЛИХГҮЙ үл ялих; *ялихгүй юмнаас шалихгүй хэрэг гарав.*

ШАЛЛАХ шал хийх, шалтай болох; *байшин шаллах; зам шаллах; чулуугаар шаллах.*

ШАЛМАА сав зэвсгийг бэхлэн хавчиж хадсан төмөрлөг; *домбоны шалмаа; хувингийн шалмаа; хавхгийн шалмаа.*

ШАЛМАГ түргэн, гавшгай, шаламгай; *шалмаг хийх.*

ШАЛМАГДАХ хэтэрхий шалмаг болох.

ШАЛМАГЛАХ бушуулах, түргэлэх, шалавлах.

ШАЛМАГРАХ шалмаг болох, шалмаг хөдлөх.

ШАЛРАХ салан задгай болох, салрах ч гэдэг.

ШАЛТАА шалтгаа.

ШАЛТААЧ юмны түрүүн шалтаг гаргадаг зантай; *шалтаачид шалтаг мундахгүй.*

ШАЛТАГ I үйл ажлаас зайлах булталх, башир, арга мэх *шалтаг балтаг* з ү й р; *аян шалтаг; аман гудас; шалтаг заах; шалтаг болгох; шалтаг хийх; шалтаг түлхэх;* **шалтаг эрэх** (өө сэв, завсар зааль хай эрэх).

ШАЛТАГ II шалтгаа, жирэмсэн.

ШАЛТАГЛАЛ шалтаглах баширлах үйлийн нэр.

ШАЛТАГЛАХ шалтаг болгох, шалтах, башир бааш гаргах, арга саам эрэх; *ялихгүй юмаар шалтаглаж ажлаас хойш суух хэрэггүй.*

ШАЛТАГЛУУЛАХ шалтаглахын үйлдүүлэх хэв.

ШАЛТАЛХИЙЛЭХ байн байн шалтах.

ШАЛТАХ үйл явдлаас зайлах булталхын тул залилах, мэхлэх, бачлах баашлах, баширлах.

ШАЛТГАА эхийн хэвэл дахь хүүхэд.

ШАЛТГААЛАХ үйл хэрэгт энэхэн тэрхнээр түлхлэг шалтаг хийж булталх, зайлсхийх.

ШАЛТГААН 1. шалтаг; **шалтаг шалтгаан** х о р ш.; 2. юмны учир чанарын нөлөө, үүсгэл холбогдол; *уг шалтгаан; учир шалтгаан; өвчний шалтгаан; хүндтэй шалтгаан; онцын шалтгаан;* 3. шалтгаа.

ШАЛТГААНГҮЙ шалтгаан байхгүй; *ямар ч шалтгаангүйгээр ажил таслах.*

ШАЛТГААНТ шалтгаан бий.

ШАЛТГААНТАЙ 1. шалтгаан бүхий; *хүндтэй шалтгаантай;* 2. шалтгаа бүхий.

ШАЛТГААЦАХ шалтаглах, шалтгаан заах.

ШАЛТУУЛАХ шалтахын үйлдүүлэх хэв.

ШАЛУУЛАХ I шалахын үйлдүүлэх хэв.

ШАЛУУЛАХ II шатарцахад эсэргүүцэл этгээдийн ноёныг морь, тэрэг, бэрсийн аль нэгээр хөллөн хэрэлдүүлэх.

ШАЛХАЙЛГАХ шалхайхад хүргүүлэх.

ШАЛХАЙХ шалхгар болох; *арьс нь шалхайх; гэдэс шалхайх.*

ШАЛХАЛЗАХ шалхгар юмны шалхас шалхас хөдлөх.

ШАЛХАЛЗУУЛАХ шалхалзахын үйлдүүлэх хэв.

ШАЛХГАНАХ шалхгар юмны шалхга шалхга хөдлөх.

ШАЛХГАР 1. зориггүй, хөдөлгөөн муутай; *шалхгар муу эр байна;* 2. өмссөн хувцасны уужим элбэг; *шалхгар өмд;* 3. сул, үлбэгэр, дорой, яданги; *сул шалхгар биетэй амьтан;* 4. тарган; *шалхгар гэдэстэй; шалхгар тарган үхэр;* 5. ш и л ж с э н идэш хоолны амтгүй муу; *шалхгар амттай хоол.*

ШАЛХГАРДАХ хэтэрхий шалхгар болох.

ШАЛХГАРДУУЛАХ шалхгардахын үйлдүүлэх хэв.

ШАЛХМАГ 1. буцламгай цагаад хүйтэн сүү ихэнх хольж хутган уух идээ; 2. хэтэрхий усархаг байдалтай болсон юм; *нүд шалхмаг болтлоо хавджээ; чанасан ногоо усан шалхмаг болов.*

ШАЛХМАГТАХ шалхмаг байдалтай болох.

ШАЛЧГАНАХ 1. шалчгар юмны шалчга шалчга хөдлөх; 2. ш и л ж с э н долдгонон нялуун зан байдал гаргах; *чи битгий шалчганаад байгаарай.*

ШАЛЧГАНУУЛАХ шалчганахын үйлдүүлэх хэв.

ШАЛЧГАР 1. нимгэн, халчгар; **нимгэн шалчгар, халчгар шалчгар** х о р ш.; *шалчгар дурдан; шалчгар тэрлэг; шалчгар исгий; шалчгар туранхай хүн;* 2. ш и л ж с э н зүрх зоригүй хулчгар дорой; *яасан шалчгар хүн бэ чи?*

ШАЛЧИГ: шалчиг шалчиг хийх, шалчиг балчиг хийх устай, шавартай газар явахад шал пал хийж чимээ гарах.

ШАЛЧИГНАХ ус, намаг, шавартай газар явахад шалчиг шалчиг хийх.

ШАЛЧИГНУУЛАХ шалчигнахын үйлдүүлэх хэв.

ШАЛЧИЙЛГАХ шалчихад хүргүүлэх.

ШАЛЧИЙХ шалчгар болох, хулчгар болох.

ШАЛЧИЛЗАХ шалчгар юмны шалчис шалчис хийх.

ШАЛЧИЛЗУУЛАХ шалчилзахын үйлдүүлэх хэв.

ШАЛЬ: шаль бүл 1. хөнгөн хуумгай гэнэхэн байдалтай; шальдар бүлдэр ч гэдэг; 2. хүний идэх уухдаа сонгож орхин, дуртай дургүй идэхий нь, шалиа бүлээ ч гэдэг.

ШАЛЬДАР: шальдар бүлдэр гэнэхэн томоотой; *шальдар бүлдэр хүүхэд юү мэдэх вэ.*

ШАЛЬДАРДАХ хэтэрхий шальдар болох, томоогүйдэх.

ШАМ: шам хийх амьтны ямар нэгэн идэх уух юмнаас хождохгүй, дутахгүйг шоодворлон өгүүлэхэд хэрэглэх үг; *шар нохой шам хийхээс хождохгүй* з үй р.

ШАМАРГА шуургалан орсон нойтон цас; **шуурга шамарга** х о р ш.; *цасан шамарга хаялж байна.*

ШАМАРГАДАХ хэтэрхий шамарга болох.

ШАМАРГАЛАХ шамарга цас орох.

ШАМАРС у р г а м а л хангайн бүсэнд ургадаг, нийлмэл навчтай, ягаавтар цэцэгтэй олон наст ургамал, тэжээлийн чанар сайн.

ШАМБАРАМ хошного хавийн венийн судас бүдүүрч молцоглох өвчин, заримдаа цус гарна.

ШАМБАРАМТАХ шамбарам өвчтэй болох.

ШАМБИГАНАХ шамбигар юмны шамбига шамбига хөдлөх.

ШАМБИГАР хүний ам, царайн байдал нимгэн шалчгар; *шамбигар амтай; шамбигар царайтай.*

ШАМБИЙЛГАХ шамбийхын үйлдүүлэх *хэв.*

ШАМБИЙХ шамбигар болох.

ШАМБИЛЗАХ шамбигар юмны шамбис шамбис хөдлөх.

ШАМДАХ 1. үйл ажилд хичээл мэрийлт гаргах; *шамдан хичээж суралцах;* 2. шаардах, шахах.

ШАМДГАЙ I ховдог, сувдаг.

ШАМДГАЙ II зан явдал гавшгай, шаламгай.

ШАМДГАЙЛАХ I ховдог сувдаг зан байдал гаргах.

ШАМДГАЙЛАХ II үйл ажилд хичээж шамдал гаргах.

ШАМДГАЙРАХ ховдог сувдаг болох.

ШАМДГАЙТАХ ховдог сувдаг зан байдал гаргах.

ШАМДУУ шамдгай яаруу хүн; **яаруу шамдуу** х о р ш.; *шамдуу хүрэлцэн очив; шамдуу ажиллах.*

ШАМДУУЛАХ шамдахын үйлдүүлэх хэв, шаардуулах, шахуулах.

ШАМЛАХ шамрах, шамруулах, шамрахад хүргүүлэх; *ханцуй шамлах.*

ШАМЛУУЛАХ шамлахын үйлдүүлэх хэв.

ШАМНАНЦ чавганц.

ШАМНАЦ шамнанц.

ШАМРАХ I 1. юмны зах сэжүүр этгээд энэ тийшээ эргэх, нугаларах; *ханцуй шамрах; хормой шамрах; цаас шамрах; арьс шамрах;* 2. юмны шантрах;*гадас шамрах; хадаас шамрах; үзүүр нь шамрах; ир нь шамрах.*

ШАМРАХ II шуургалан цас орох; **шуурах шамрах** х о р ш.; *цасаар шамрах.*

ШАМШГАР 1. хүний уруул хамар шалчгар нимгэн байдалтайгий нь; *шамшгар уруултай;*

шамшгар хамартай; 2. юмны хэв хэлбэр эвдэрч хэвийн жишээнээс навшгар, шамбигар болсны нь; *шамшгар хувин; шамшгар сав.*

ШАМШИГДАЛ шамшигдсан юм; **үрэгдэл шамшигдал** х о р ш.; *шамшигдал багатай; шамшигдалгүй.*

ШАМШИГДАХ шамшихын үйлдэгдэх хэв, үрэгдэх, бүрэлгэгдэх, сүйтгэгдэх; **үрэгдэх шамшигдах** х о р ш..

ШАМШИГДУУЛАГЧ шамшигдуулсан этгээд; *олон нийтийн хөрөнгийг идэж шамшигдуулагчидтай хатуу тэмцэх хэрэгтэй.*

ШАМШИГДУУЛАХ шамшигдахын үйлдүүлэх хэв; үрэгдүүлэх, бүрэлгэх, сүйтгэх; *сангийн эд хөрөнгийг шамшигдуулах; хамтын хөрөнгийг шамшигдуулах.*

ШАМШИГЧ шамшсан этгээд; *эд хөрөнгө шамшигчидтай эрс тэмцэл хийх.*

ШАМШИЙЛГАХ шамшийхад хүрүүлэх, шамшгар болгох.

ШАМШИЙХ шамшгар болох, навшгар болох.

ШАМШИХ юмыг завшин ашиглах, үрж бусниулах; *улсын хөрөнгийг шамших; бусдын юмыг завшин шамших; юмыг ашиглан шамших.*

ШАМШУУЛАХ 1. шамшихын үйлдүүлэх хэв; 2. шамшигдах.

ШАН I 1. шатнал болгож өгөх юм, урамшуулан олгох хэшиг, хувь; **хэшиг шан, хувь шан** х о р ш.; *шан өгөх; шан хүртээх; мөнгөн шан олгох;* 2. өртөг, хөлс; **өртөг шан, хөлс шан** х о р ш..

ШАН II тариалангийн газрын хоёр далангийн хоорондох газар; *тарианы шан.*

ШАН III нэг зүйл шаа торго.

ШАНАА (Н) 1. х у у ч и р с а н хүн амьтны чихний доод эрүүний үзүүрийн муруйн орчин газар; 2. нүдний харалдаа хоёр хажуугийн хэсэг газар; *шанааны яс; шанааны ус.*

ШАНААРХАГ өргөн шанаатай, шанаа ихтэй.

ШАНААРХУУ шанаархаг.

ШАНАГА (Н) юм хум утгах том халбага; **тогоо шанага, шанага халбага** х о р ш.; **ингэн шанага** (маш том шанага): **шанаган илүүр** (дотор нь цог улайлгаж халаадаг, шанагын адил хэлбэртэй илүүр); **шанаган шүүр** (шанаганы адил бөгөөд шингэн зүйл шүүрч гарах нүхтэй, юм **хум шүүрдэж авах** хэрэгсэл); **шанаган хорхой** а м ь т а н (мэлхийн зүлзага, сүүлтэй, усанд оршиж заламгайгаар амьсгална, шанаганы адил дүрстэй).

ШАНАГАЛАХ юмыг шанагаар хэмжих; *сүү шанагалах; тариа будаа шанагалах; давс хужир шанагалах.*

ШАНАГАЛУУЛАХ шанагалахын үйлдүүлэх хэв.

ШАНАЛАЛ шаналах үйлийн нэр; **энэлэл шаналал** х о р ш.; *шаналал ихтэй; шаналал багатай.*

ШАНАЛАХ зовох, энэлж зовиурлах; **зовох шаналах, энэлэх шаналах** х о р ш.; *өвчинд шаналах; сэтгэл зовж шаналах.*

ШАНАЛГА шаналал, зовлон, зүдүүр шаналгаа ч гэдэг; *шаналгатай өвчин; шаналгатай хүн.*

ШАНАЛГАТАЙ шаналга бүхий; *шаналгатай өвчин; сэтгэлийн шаналгатай хүн.*

ШАНАЛУУЛАХ шаналахын үйлдүүлэх хэв.

ШАНАРУУ а м ь т а н байдал малрын адил, бие жижигхэн, буга үхэр зэргийг шоглох зантай нэгэн зүйл амьтан.

ШАНГУУНА тахиа шувууны өөр нэр.

ШАНД бяцхан булаг ус; **булаг шанд** х о р ш..

ШАНДАН цууямбуутай төстэй бөгөөд нэхээс нягттай нэг зүйлийн бөс бараа; *шандан даавуу; торгон шандан; шандан хөшиг.*

ШАНДАС 1. амьтны шөрмөс; **шандас шөрмөс** х о р ш.; 2. булчингийн хүч; *шандастай залуу; шандас сайтай бөх; шандастай морь; савваа шандас, ноос мяндас* (эсгийн ерөөл).

ШАНДАСТАЙ 1. шандас бүхий, шандсархаг; 2. ш и л ж с э н тэсвэртэй.

ШАНДАХ 1. өөх тос зэргийн хурц нүнжигтэй зүйлийг идэж дур тааламжгүй болох, шандуурах ч гэдэг; *дотор бялайж шандаж тун аягүй байв;* 2. ш и л ж с э н дэн зул мэтийн тос нь ихэдсэнээс буюу гол нь нарийссанаас болж гэрэл нь муудах ба асахгүй унтрах; *зул шандаад асах нь муу байна.*

ШАНДСАРХАГ шандас сайтай, шандас ихтэй, булчингийн хүч чадал сайтай.

ШАНДСАРХУУ шандсархаг.

ШАНДУУРАЛТАЙ шандуурмаар байдалгай.

ШАНДУУРАХ шандах; *өөхөнд шандуурах; чихэрт шандуурах.*

ШАНДУУРУУЛАХ шандуурахын үйлдүүлэх хэв.

ШАНЗ I гурван чавхдастай бөгөөд нэг гараар чавхдасыг дарж нөгөөгөөр цохьдог чавхдаст хөгжмийн зэвсэг, хайрцгийн хоёр талыг могойн арьсаар царлана, шудрага ч гэдэг.

ШАНЗ II хүнсний зүйлийн дотоодод атуулахаар амталж найруулсан идээний зүйл; *баншны шанз; чихрийн шанз; шанзтай чихэр.*

ШАНЗДАХ шанз хөгжмөөр хөгжимдөх.

ШАНЗДУУЛАХ шанздахын үйлдүүлэх хэв.

ШАНЗЛАХ шанз идээ найруулах.

ШАНТАЙЛГАХ шантайхын үйлдүүлэх хэв, шантгар болгох.

ШАНТАЙХ 1. шантгар болох; 2. хамраа атриулан ярдайх; 3. хилэгнэж ихээр зан гаргах.

ШАНТАЛЗАХ шантгар юмны шантас шантас хийх.

ШАНТАЛЗУУЛАХ шанталзахын үйлдүүлэх хэв.

ШАНТГАНАХ шантгар юмны шантга шантга хийх.

ШАНТГАНУУЛАХ шантганахын үйлдүүлэх хэв.

ШАНТГАР 1. хүн амьтны хамар хушуу суунгий нь; *шантгар хамартай хав;* 2. зарим юмны ээтэн еэтгэр хэлбэртэйгий нь; *шантгар хамартай гутал.*

ШАНТЛАХ шантрахад хүргүүлэх, шантруулах.

ШАНТЛУУЛАХ шантлахын үйлдүүлэх хэв.

ШАНТРААХ шантруулах, мохоох, бууруулах, няцаах.

ШАНТРАХ 1. юмны үзүүр ир шамлагдан мохох; *гадас шантрах;* 2. шилжсэн бэрхшээж зүрхших; *ажлаас шантрах; зүрх шантрах;* 3. шилжсэн урам зориг мохох буурах; *зориг шантрах; дур сонирхол шантрах.*

ШАНТРУУЛАХ шантрахын үйлдүүлэх хэв.

ШАНХ (АН) 1. хүний хоёр шанаанд унжсан үс; *шанх үс;* 2. эмэгтэйчүүдийн магнайн үс мөн үсийг хагалбарлан янзалж зассаны нь; *шанх наах; шанх тавих;* **шанхан дэл** (морины дэлийн хагалбартайгий нь).

ШАНХАВЧ шанх үсийг даруулж боох тууз мэт зүйл.

ШАНХАН: шанхан бялзуухай алтан гургалдай шувууны өөр нэр; **шанхан загас** (гутаар загасны өөр нэр).

ШАНХАР: шанхар галуу амьтан хээрийн галууны дотроос хамгийн том, улаан хушуутайгий нь: **шанхар нугас** амьтан (ногтмол нугасны адил, жигүүртээ цагаан бидэртэй, нисэхдээ заавал дуугардаг нугас).

ШАНХАТ: шанхат малгай эхнэр хүний үсийг хурааж өмсөх нэг зүйл малгай.

ШАНХЛАГ хиймэл шанх үс.

ШАНХЛАХ 1. эмэгтэйчүүдийн шанх үсээ янзалж засах; 2. эмэгтэйчүүдийн толгойн үсийг гөрж ороож боох.

ШАНХЛУУЛАХ шанхлахын үйлдүүлэх хэв.

ШАНЦАГЛАХ үйл ажил завсар зайгүй шахцаж давхцах.

ШАНЦАЙ давсаляж дарсан ногоо; *шанцайтай хоол.*

ШАР I амталсан эр үхэр; *монголын шар; хайнагийн шар; сарлагийн шар;* **амбан шар** (нас гүйцэж жагссан маш том шар).

ШАР II алт мэт өнгө; **шар улаан, өндөгний шар** (өндөгний дотоод шар); **шарыг үзэж шарвах, улааныг үзэж урвах** (хүний урвамтгай тогтворгүй байдлыг зааж өгүүлэхэд хэлэх үг); **ангир шар** (улбар шар); **ангир шар улаан** (сүүн тэжээлт амьтны төрсний дараа хөхнөөс нь гарах уургийн зүйлээр элбэг өтгөн сүү; *арван сар ангир шар уургаа хөхүүлсэн* аман зохиолоос); **шар үсний нүх, шар үсний сүв** хүний арьсанд буй үсний сүв, энэ сүвээр хөлс зэрэг ялгадасны зүйл гарахаас гадна бас амьсгална); **шар ус** (а. хүн амьтны бие махбодод байх цусны шингэн; б. амьтны биед цусны шингэн хуралдан тогтсон өвчин; в. яр шархнаас цуврах шаравтар ус; г. хатуу хөрөнгөнөөс шүүрсэн ус; д. аарц тараг ээдэм зэргээс шүүрэн гарах ус; е. гол усны мөс цас хайлж гарсан хальдас ус); **шар сүү** (а. бяслаг шахах, ээзгий буцалгах, сүүг ээдүүлэхэд ялгаран гарах шингэн зүйл; б. сүү цагааг хольж буюу дан цагааг шүүхэд түүнээс ялгаран гарах шингэн зүйл); **шар ус** (хүний бүх биед байдаг нарийн ус); **шар хув (өнгө шар бөгөөд**

тунгалаг, давирхайлаг хатуу эд); **шар зос** (өнгө нэг зүйл зос); **шар тос** (малын сүү цагаан идээнээс ялгаж авах тос; *нохойн гэдсэнд шар тос зохихгүй* з ү й р); **шар хальс** (а. махны гадна талын өнгө хальс; б. арьс ширний хөрсөнд наалдсан махны хальс; в. ургамал үрийн нимгэн хальс); **шар феодал** (лам феодал); **шар малгайтан** (Буддын шашны нэг зүйлийн салбар, шар малгай өмсөнө, Зонховын шашинтан); **шар цай** (а. шахмал ногоон цайг найм хуваасны нэг; б. хуучин цагийн мөнгөний нэгж болох цаасанд боосон задгай цай; в. зарим орон нутагт хэрэглэж байсан тийз хэмээх мөнгөн тэмдэгт); **шар өвчин** (элэгний халдварт өвчин, арьс шар өнгөтэй болно); **шар үсэг** (татлан бичсэн нэг зүйл төвд үсэг); **намрын шар нар** (намар цагт гарах нар); **шар хальслаг** (нэг зүйл жимс, жижиг чавга шиг, хальс шар); **шар эм** у р г а м а л (ухрийн хэлтэй адил навчтай, улаавтар ногоон иштэй, луувангийн адил үндэстэй, гашуухан амттай нэгэн зүйл ногоо): **шар орионго** у р г а м а л (өвс тариандороож зэллэн ургадаг нэгэн зүйл ногоо, үрий нь эмнэлэгт хэрэглэнэ); **шар бударгана** у р г а м а л (бор шар дурстай, заг сухайн адил найлзууртай бөгөөд үслэг, жижигхэн хүрэн бор үртэй нэг зүйл ургамал, үрийг иддэг, шээс элбэгших өвчинд хуурай идвэл сайн гэдэг); **шар боролзой** у р г а м а л (ихээхэн хужирлаг газраас бус ямар нэгэн газар ургадаг нэг зүйл ургамал, өндөр нь нэг төөгөөс илүү, үнэр амт шим чадал боролзойн адил боловч ногоон цагт нь мал идэх дургүй); **шар сараана** у р г а м а л (хээр ургадаг нэгэн зүйл ургамал, навч шар буурцгийн навчтай адил, язгуурт цагаан шүүс бий); **шар хойч** у р г а м а л (ойт хээрийн бүсэнд тал бэл газраар ургадаг олон наст ургамал, бас тоос ихтэй); **шар удвал** у р г а м а л (асга хадтай газрын сүүдэр дагаж ургадаг нэг зүйл удвал, цэцэг шар өнгөтэй; эмнэлэгт хэрэглэнэ): **шар зээргэнэ** у р г а м а л (говь цөл газар ургадаг нэг зүйл зээргэнэ, тэмээ зэрэг малд тохиромжтой); **шар хялгана** у р г а м а л (гол горхины дагуу намагдуу, нуга газраар ургадаг олон наст ургамал, хялганатай төстэй нарийн иштэй, малд сайн тэжээл болно); **шар цахилдаг** у р г а м а л (гол төлөв ойт хээрийн бүс, ой тайгын бүсэнд ойн хаяа мод сийрэг газраар ургадаг шар өнгийн цэцэгтэй нэг зүйл цахилдаг); **шар буурцаг** (буурцгийн нэгэн зүйл үр, өнгө шар); **шар төмс** у р г а м а л (ойт хээрийн бүс, ой тайгын бүсэнд модны хаяа болон сийрэг ойд ургадаг нэг зүйл зэрлэг төмс, цэцэг нь цагаан толботой ягаавтар өнгөтэй); **шар мод** у р г а м а л (хангай нутгийн өндөр уулын оройгоор ургадаг, өргөстэй жижиг сөөгөн ургамал); **шар яргуй** у р г а м а л (ойн хаяагаар ургадаг нэг зүйл яргуй, тавдугаар сард цэцэглэнэ, цэцгийн өнгө шар, төрөл бүрийн малд сайн тэжээл болно); **шар шаваг** у р г а м а л (говь цөл газар ургадаг нэг зүйл шарилж); **шар мөөг** у р г а м а л (модонд ургадаг шаравтар өнгөтэй нэг зүйл мөөг, идшинд хэрэглэж болно); **шар өлөн** у р г а м а л (чийгтэй нуга газраар ургадаг нэг зүйл улаалж өвс); **шар харгай** у р г а м а л (цөөрсний намын нэгэн зүйл, хөнгөн бат мод); **шар лууван** у р г а м а л (амттайхан шаравтар өнгийн үндэстэй идэшний ногоо, үндсийг иднэ); **шар маахай** (нас бие гүйцэж жагссан том баавгай); **шар ирвэс** а м ь т а н (биедээ зоос шиг бидэртэй нэгэн зүйл ирвэс): **шар ураацай** а м ь т а н (нүдний цэцгий улаан хар, чандар жигүүр сүүлд шар хольцолдсон нэгэн зүйл шувуу); **шар божирго** а м ь т а н (үнсэн шар чандарт хар бидэр бүхий нэгэн зүйл божирго шувуу); **шар хөмсөг** а м ь т а н (хятруу бялзуухайтай адил, хушуу жигүүр хар, хөл улаан, хөмсөг шар нэг зүйл бялзуухай); **шар тоть** а м ь т а н (тотийн хамгийн жижиг нь бөгөөд толгой эрүү жигүүр ногоон, хүзүү омруу шар нэгэн зүйл тоть); **шар шувуу** а м ь т а н (жигүүр богино, өд няг болоод хөндлөн харавтар судалтай, өдөн чихтэй, хушуу богино, шөнө явдаг нэгэн зүйл махчин шувуу); **шар зөгий** а м ь т а н (их бие нь шар эрээн нэгэн зүйл зөгий, хүн малыг ээрч хатгана).

ШАР III хүний идсэн хоол унд хэт исч, түүнээс олох өвчин; *айргийн шар; архины шар; шар тайлах;* **шар дэврэх, шар нь дэврэх** (шар хөөрөх өвчин тохиох); **шар хусах** (хүний идсэн юм исч уур болж дээш оргих); **шар авах** (бусдыг байн байн хашруулан зовоох); **шар цус хөөрөх** (нүд эрээлжлэн толгой эргэж, дотор муухай болж ухаан балардах); **шар хөдлөх, шар нь хөдлөх** (а. шар хөөрөх өвчин дахин сэргэх; б. уур омог нь сочмог дэврэх); **шар хөөрөх, шар нь хөөрөх** (а. шар хусах; б. уур омог нь бадрах).

ШАР IV уур, омог; **шар гаргах** (омогтой зан гаргах).

ШАР V юмны шаржигнан гарах чимээ; *цасан дээр гишгэхэд шар хийх чимээ гарав;* **шар шир хийх, шар шор хийх, шар шур хийх** (шар хийсэн чимээ байн байн гарах).

ШАРАВТАР цайвархан шар өнгө.

ШАРАВЧ цайвар шар бидэртэй улаан хэрээ; *шаравч хэрээ.*

ШАРАГДАХ шарахын үйлдэгдэх хэв, ээгдэх; *наранд шарагдах; галд шарагдах.*

ШАРАГЧИН эм амьтны шар зүстэйгий нь; *шарагчин туулай; шарагчин үхэр.*

ШАРАЛГАХ тарчилган зовоох, шарлаах ч гэдэг.

ШАРАЛХАХ дээрэнгүй омог гаргах, дээрэлхэх, омгорхох.

ШАРАМ хурц бөгчим халуун илч, шармаар ч гэдэг; *шарам халуун.*

ШАРАМДАГ модыг ховхидоход хусагдаж гарсан харуулдас хог.

ШАРАНГУЙ юмны шаравтархан өнгө.

ШАРАХ 1. идээний зүйлийг галд түлж болгох; *мах шарах; мөөг шарах;* 2. юмыг халуун илчинд ээх, цоноох; *биеэ наранд шарах; гэрэлд шарах;* 3. өнгөт металлыг юманд түрхэж өнгөлөх; *алт шарах; мөнгө шарах;* **нэр шарах** (а. нэр хүлээх; б. нэр гутаах).

ШАРВААХ шарвуулах, шарвахад хүргүүлэх.

ШАРВААЧ урвах буцах зантай; *ноён урваач, нохой шарваач* з ү й р.

ШАРВАГАНАХ шарвалзах.

ШАРВАЛЗАХ 1. морь мал сүүлээ сэгсэрхийлэх, байн байн шарвах; 2. хүнд эрхлэн нохой сүүлээ хөдөлгөх; *сүүлээ шарвалзах;* 3. бусдад эрхлэх санаагаар элэгсэг найр үзүүлэн аашлах; 4. хүн амьтны үйл ажилд тэсэхгүй бэрхшээх байдал гаргах.

ШАРВАЛЗУУЛАХ шарвалзахын үйлдүүлэх хэв.

ШАРВАХ 1. морь малын, сүүлээ шарваж хөдөлгөх; *сүүлээ шарвах;* 2. тэрэг чарга мэтийн юмны халтираа гулгариатай газар халтирах гулгарих; *тэрэг шарвах; машина шарвах;* 3. ш и л ж с э н ачсан ачаа нэг тийш дийлж хазайх; *ачаа шарвах;* 4. ш и л ж с э н урвах буцах, биеэсээ зайцуулах; **урвах шарвах** х о р ш..

ШАРВИГАР үс ургамал зэргийн сийрэг, ширүүн байдалтайгий нь; *шарвигар сахал; шарвигар өвс.*

ШАРВИГНАХ базаахгүй царай гаргах; *тэнгэр шарвигнан муухай аашлах; аавын шарвигнадаг нь хөдөлж орхижээ.*

ШАРВИЙХ шарвигар болох, шарвигар байдал гаргах.

ШАРВИР шаравтар бор өнгө.

ШАРВУУЛАХ шарвахын үйлдүүлэх хэв.

ШАРГА дагаан шаравтархан өнгөтэй адууны зүс; *шарга морь; шалзат баахан шаргаараа хөө, шаргын говийг туулна даа хөө* (ардын дуу).

ШАРГААХ I 1. шаргахад хүргүүлэх, шаргуулах; 2. бусдаас байн байн юм асуух нэхэх зэргээр шаардаж шалгаах, хоргоох, **шалах шаргаах, шалгаах шаргаах,** *манай хүү гутал авч өг гэж шаргаагаад суулгахгүй болов.*

ШАРГААХ II өөх, холимог тосыг ширгээн буцалгаж цэвэр тос гаргаж авах; *дотор өөх шаргаах; өөх шаргаах.*

ШАРГАГЧИН эм зээр; *шаргагчинг хамаагүй алж болохгүй.*

ШАРГАЛ цагаанд улаавтар шар хольцсон өнгө; *шаргал морь; шаргал хулдаас.*

ШАРГАХ I 1. ямар нэгэн юмыг бусдад хялбар тавьж өгөхгүй маргах булаалдах; 2. тарвага зэрэг амьтны яргах.

ШАРГАХ II шаргаах II.

ШАРГУУ нөр, цөлх, шамдуу, хичээлтэй; *шаргуу ажиллах; шаргуу тулалдах; шаргуу хэлэлцэх.*

ШАРГУУЛАХ шаргаахын үйлдүүлэх хэв.

ШАРД: шард хийх, шард гэх юмнаас шар хийсэн чимээ гэнт гарах.

ШАРЖИГНАХ юмнаас шар шар хийсэн чимээ гарах; *шаржигнах чимээ гарах чинь юу вэ?*

ШАРЖИГНУУЛАХ шаржигнахын үйлдүүлэх хэв.

ШАРЗ арз архийг нэрж гаргасан архи.

ШАРЗАН хярзан.

ШАРИЛ хүндэтгэвэл зохих хүний хүүр; **шарил хайлах** (шатаах); **шарил бүтээх** (шарилы нь засч хэвийн байдалд хатаах).

ШАРИЛЖ 1. у р г а м а л нийлмэл цэцгийн язгуурын нэг төрлийн ургамлын ерөнхий нэр, төрөл зүйл олон, *морин шарилж, хонин шарилж; цагаан шарилж; бор шарилж; өмхий шарилж;* **хамба шарилж** у р г а м а л (ойт хээрийн бүс, ойт тайгын бүсэнд, сийрэг ой модны захаар ургадаг бөгөөд нийлмэл цэцгийн язгуурт багтах дугуй том цэцэгтэй олон наст ургамал, эмнэлэгт хэрэглэнэ); **шарилж сойх** у р г а м а л (шарилжийн нэгэн зүйл, иш шулуун, навчны гадар этгээд цагаавтархан, навчийг хатааж эмнэлэгт хэрэглэнэ); 2. гол төлөв буурцархаг газраар ургадаг хогийн ургамлууд; *шороң гяндангийн орон дээр, шарилж өвс ургавал, шаналан зовсон минь, санаа сая ханана* (Д. Нацагдорж).

ШАРЛААХ 1. шарлахад хүргүүлэх, шарлуулах; 2. тарчилган зовоох, зүдэргэх, шаралгах ч гэдэг.

ШАРЛАХ I 1. шар болох; *мод шарлах; өвс шарлах;* **үүр шарлах, гэрээ шарлах** (үүр тэмдгэрч шар гэгээ гарах); 2. шар өвчин хүрэх; *шарлах өвчнийг анагаах.*

ШАРЛАХ II хүн амьтны зовж зүдрэх, тарчлах; *хувьсгалын өмнө амьдрах гэж мөн ч шарлаж явлаа би.*

ШАРЛУУЛАХ I шарлах I-ийн үйлдүүлэх хэв, шар болгох.

ШАРЛУУЛАХ II шарлах II-ын үйлдүүлэх хэв, зовоож зүдрээх, шарлаах ч гэдэг.

ШАРЛУУЛАХ III өөх тосыг хайлуулж цэвэртгэх; *тос шарлуулах; өөх шарлуулах.*

ШАРМИГАР нимгэн сармигар.

ШАРМИЙЛГАХ шармийхын үйлдүүлэх хэв.

ШАРМИЙХ шармигар болох, шармигар байдал гаргах.

ШАРНАД цөөвөр.

ШАРСХАН у р г а м а л хав загас мэт хавтгай хэлбэртэй, хушганы идээний адил амттай, зөллэж ургадаг нэгэн зүйл жимс.

ШАРТАЙ ууртай, омогтой, дээрэлхүү.

ШАРТАХ 1. согтох ундааныг хэтэртэл ууж согтсоны дараа дотор аягүй болох; *архинд шартах; айраг шартах;* 2. хоол унд зохисгүйдэж дотор өвдөн шар хүсах, бөөлжих; *шартаж шараар бөөлжих.*

ШАР ТОС шар тос.

ШАРУУЛАХ 1. шарахын үйлдүүлэх хэв; 2. шарагдах.

ШАРХ хүн амьтны арьс мах ямар нэгэн шалтгаанаар ялтарсан хагарсны цармы нь; **яр шарх, шарх сорви** х о р ш.: *шарх боох; шарх гарах; шарх аних; шарх битүүрэх; шарх сэдрэх; сумны шарх; хутганы шарх.*

ШАРХАТ шархтай.

ШАРХИРАА үе мөч, булчин шархирч өвдөх нэгэн зүйл өвчин; *хөлийн шархираа улам нэмэгдэж байна; биеийн шархираа ер намжихгүй болов; шархираа өвчин.*

ШАРХИРАХ хүний шөрмөс, яс мах унжирч шимшрэн өвдөх; *гар шархирах; өвдгөөр шархирах; шилбэ шархирах.*

ШАРХИРУУЛАХ шархирахын үйлдүүлэх хэв.

ШАРХЛАХ шарх олох, шархтай болох; *гар шархлах; хөл шархлах; уушиг шархлах.*

ШАРХТАЙ шарх бүхий; *шархтай хуруу битгий хөндчих чи; шархтай гөрөөс.*

ШАРХТАН шарх бүхий хүмүүс; *хүнд шархтан; хөнгөн шархтан.*

ШАРХТАХ шарх олох, шархтай болох; *толгой шархтах.*

ШАРХТУУЛАХ шархтахын үйлдүүлэх хэв.

ШАРХЧ сэжигтэй үхсэн хүний шархыг шинжлэн үзэгч хуулийн албаны хүн.

ШАРХШИХ шарх шинжтэй болох.

ШАРЦ 1. янз үзмийн адил болоод зөллэж ургадаг нэг зүйл жимс: 2. ялзарсан царс модны дурсны дотоод дахь шар өнгийн эд, арьсыг шар өнгөөр будахад хэрэглэнэ; 3. у р г а м а л нохойн хушууны мод.

ШАРЧГАР саржгар, шалчгар.

ШАРЧИГНАХ шажигнах, шар шар хийх чимээ гарах.

ШАРЧИГНУУЛАХ шарчигнахын үйлдүүлэх хэв.

ШАРЧИЙХ шарчгар болох.

ШАСТАР үеэс үед уламжилж ирсэн түүхийн бичиг, шашдар ч гэнэ; **түүх шастар, сударшастар** х о р ш..

ШАТ I 1. өндөр өөд авирахад хэрэглэх хэрэгсэл; төмөр мод, чулуу мэтээр хийнэ, зүйл ялгал олон; *олсон шат; модон шат; чулуун шат; цахилгаан шат; дүүжин шат;* 2. үе, зэрэг дэв, алхам; *анхан шатны сургууль; намын анхан шатны байгууллага; боловсролын талаар шат ахих; империализм бол капитализмын дээд шат мөн.*

ШАТ II тэмээ хомноход хэрэглэх хэрэгсэл, цавчиж зассан хоёр хэсэг нарийн модны дунд хирд бяцхан сэрвээ хийж, доогуур нь хэлхэж өмнөд хойдыг холбож хэрэглэнэ; **хом шат, шат бамбай** х о р ш..

ШАТААГДАХ шатаахын үйлдэгдэх хэв.

ШАТААГЧ шатаах үйл гүйцэтгэгч этгээд: шатаадаг юм; **шатаагч бөмбөг** (дотроо шатах бодис бүхий бөмбөг).

ШАТААЛГАХ 1. шатаахад хүргүүлэх; 2. шатаагдах.

ШАТААХ шатахад хүргүүлэх; *гал шатаах; ууры нь шатаах; дайн шатаах.*

ШАТАЙ морь малын туурай элсний нь,

ШАТАМТГАЙ шатамхай.

ШАТАМХАЙ шатахдаа маш хялбар, хялбар шатдаг, шатамтгай.

ШАТАР бүгд арван зургаан дүрсийн хос юмыг хоёр этгээд нэжгээдээр эзлэн, тусгай хөлөгт жагсаан өрж, хоёр этгээд талцаж наадах тоглоом; *монгол шатар; нийтийн шатар; шатрын аврага; шатрын тэмцээн; шатрын онол; шатрын ноён шатрын хүү; шатрын хөлөг;* **шатар тавих** (шатраар тоглох).

ШАТАРЦАХ шатраар наадах.

ШАТАРЦУУЛАХ шатарцахын үйлдүүлэх хэв.

ШАТАРЧ (ИН) шатар сайн тоглодог хүн; *нэгдүгээр зэргийн шатарчин.*

ШАТАРЧЛАХ юмыг шатар маягаар үйлдэх; *шатарчилж барилдах.*

ШАТАХ 1. гал ноцох; *түймэр шатах; гал шатах;* **шатах хий** (ус төрөгч, нүүрс төрөгчийн исэл, метан зэрэг асах чанартай хий); **шатах занар** (шатах шим бодисоос тогтсон, нимгэн нимгэн давхрага бүхий чулуулаг): **шатах бодис** (шатах юмс); 2. шилжсэн уур хилэн гэнт бадрах; *уур шатах;* 3. шилжсэн дайн дажин үүсэх; *дайн шатах.*

ШАТАХУУН шатдаг хэрэглэгдэхүүн; *машины шатахуун; шатахууны зүйл; шатахуун хэмнэх.*

ШАТЛАЛ аливаа нэгэн юм нөгөөд шилжин орох дараалал, үелэл.

ШАХ шагаа харвахад өөр өөрийн эзэлсэн тэмдэгт шагаа.

ШАХАА (Н) хуучирсан урьдын цагт хэрэглэж байсан мухар сүсгийн холбогдолтой нэгэн зүйл цээрлүүлэг;заалдсан заалдагдсан хоёр этгээдэд хөндлөн гэрч тэмдэг, сэжиг сэдэв үгүй бөгөөд хагалбар болгох зүйлгүй учир бузар муухай юмны доогуур шургуулан ам алдуулж тангараглуулдаг ес; *шахаан өгөх.*

ШАХАГ цахиур бууны дарь агуулах эвэр сав; *нэг шахаг дарь.*

ШАХАГДАХ шахахын үйлдэгдэх хэв, хавчигдах, дарагдах, тулгагдах.

ШАХАМ ямар нэгэн тоо хэмжээнд хүрэх ойртох, *арав шахам; зуу шахам; цаг шахам; өдөр бүр шахам; хоёр жил шахам.*

ШАХАМДАХ 1. гачигдаж цухалдан тачаадах; 2. яарч бачимдах, тэвдэх.

ШАХАМДУУ 1. бачимдуу, тэвдүү, яаруу; 2. маш цухалдуу, хүлцэд тэсвэр тэвчээргүй.

ШАХАМДУУЛАХ шахамдахын үйлдүүлэх хэв.

ШАХАРДАХ 1. сандарч бачимдах, уймарч тэвдэх; 2. бусдыг зандах, хавчих хяхах.

ШАХАРДУУЛАХ шахардахын үйлдүүлэх хэв.

ШАХАХ I 1. юмыг **бөөгнөрүүлж** няг чигж болгох; *бяслаг шахах; чихцэж шахах; шал шахах; шахаж суух хэрэгтэй;* 2. юманд байгаа зүйлийг ялган гаргаж авах; *өөх шахах; ур тариа шахах; идээ бээрий нь шахах;* **шахаж зайлуулах** (а. шахаж гаргах; б. түлхэж түрж байраас шилжүүлэх); **шахаж гаргах** (хяхан хавчиж зайлуулан холдуулах); 3. ойр болох, дөхөх; *ирэх шахаж байгаа; дуусах шахаж байна; очих шахаж байгаа бий; хүрэх шахаж билээ; баяр болох шахаж байна;* 4. хавчих, хаших, хүчлэх; *хонио усаар шахаж гаргах; морио хаданд шахаж байгаад барьж авав;* **багалзуур шахах** (багалзуурын тус газраас гараар базах); **багалзууры нь шахах** (бусдын багалзуурыг базаж шахах); **багалзууруа шахах** (өөрөө хоолойгоо чаргадуулах); **хоолойгий нь шахах** (бусдын хоолойг базаж шахах); **хоолой шахах** (хоолой чаргадуулах); **хоолойгоо шахах** (өөрөө хоолойгоо чаргадуулах): 5. идэшний малыг бордож таргалуулах; *үхэр шахах; гахай шахах.*

ШАХАХ II 1. тулган шаардах; **шахах шаардах** хор ш.; *идэж уухыг шаардаж шахах; үг өчгийг асууж шахах; өр төлбөрийг нэхэмжилж шахах; хэрэг заргыг байцааж шахах; айргаар шахах; архиар шахах;* 2. хуучирсан урьдын цагт, үйл хэргийн үнэн зөвийг батлуулан тангараглуулахаар цахаанд оруулж шургуулах; *шахаа шахах.*

ШАХИНАХ чахран дуугарах, чахрах.

ШАХИНУУЛАХ шахинахын үйлдүүлэх хэв.

ШАХИР ургамал шидийн шиврээс өндөрхөн, шидийн боргоцойтой адил бөгөөд бяцхан шуумгай буурцагтай, нимгэн хальстай нэгэн зүйл мод.

ШАХЛАГА 1. шахах үйлийн нэр; *шахлага сайтай; шахлаг муутай; бяслагийн шахлага;* 2. шаардлага, хавчлага; **шахлага шаардлага, шахлага хавчлага** хор ш..

ШАХМАЛ I шахаж хийсэн юм; *шахмал хужир; шахмал цай.*

ШАХМАЛ II зориуд бордож таргалуулсан эр үхэр, залуу насны бодон гахай; *шахмал шар; шахмал гахай; шахмал бодон.*

ШАХТАС юмыг шахаад үлдсэн хэсэг.

ШАХУУ I шахцасан чигжүү.

ШАХУУ II шахам; *арав шахуу хонь; хүрэх шахуу хоол; сар шахуу хугацаа; өдөр тутам шахуу хийдэг ажил.*

ШАХУУЛАХ 1. шахахын үйлдүүлэх хэв; 2. шахагдах.

ШАХУУР юмыг хавчин дарж шахахад зориулж хийсэн хэрэгсэл; *шахуур мод; шахуур гархи; эрхний шахуур.*

ШАХУУРГА 1. аяганы алчуур зэргийн савны ам амсрыг шахахад тохируулсан гархи бөгж мэтийн юм; 2. шахуур.

ШАХУУТ эмэгтэйчүүдийн төрөх тун ойртсоныг; *шахуут эмэгтэй.*

ШАХЦАГДАХ шахцахын үйлдэгдэх хэв.

ШАХЦАЛДААН шахцах үйлийн нэр.

ШАХЦАЛДАХ шахцахын үйлдэлдэх хэв.

ШАХЦАХ багтаж **ядан чихцэх.**

ШАШДАР шастар.

ШАШИН бурхан сүнс гэх мэтийн ер бусын хий хоосон зүйлд шүтэх бишрэх тэргүүтний цогц болох үзэл суртлын нэг зүйл давхрага; **шашин шүтлэг** х о р ш.; *шашны номлол; шашны суртал; шашны эсрэг сургаал;* **бөөгийн шашин** (хүй нэгдлийн байгуулал задарч ангит нийгэмлэг бий болох үед ихэд хөгжсөн нэг төрлийн шашин); **лалын шашин** (манай эрний 7-р зууны үед Араб оронд үүсч хожим бусад нутаг газар дэлгэрсэн нэг зүйл шашин); **бурханы шашин** (манай эрний өмнөх мянган жилд Энэтхэгийн умард оронд үүсч дэлгэрсэн нэг зүйл шашин); **ламын шашин** (төвд монголд ихэд дэлгэрсэн, бурханы шашны нэг хэлбэр); **христос шашин** (дэлхий дээр ихэд дэлгэрсэн шашнуудын нэг бөгөөд Иисус Христ бурхныг шүтэх шашин).

ШЕВИОТ 1. гадуур хувцас зэрэг **зүйл** үйлдэхэд зориулж хийсэн **даавуу**; 2. **мөн даавуугаар** хийсэн хувцас.

ШЕВРЕТ хонины арьсыг боловсруулан **хийсэн** эдлэл, гутал малгай зэрэг зүйлийн гадар хийнэ.

ШЕВРО ямааны арьсыг боловсруулан **хийсэн** эдлэл, гутал зэрэг юм хийнэ.

ШЕФ нэг байгууллагаас нөгөөд соёл болон бас бус тусламж үзүүлэн ажиллах **ажиллагаа**; *шефийн холбоо байгуулах.*

ШИВ I хов: **хов шив** х о р ш.; **шив хийх** (а. хатгах зэвсгийн, юманд даацтай орох; *сум шив хийтэл шигдэв;* б. бусдад сэмхэн хов хүргэх).

ШИВ II хүч нэмэгдүүлэх үг, маш, цоо; *шив шинэ хувцас; шив шинэ ажил; шив шинэхэн ханилсан хоёр залуу.*

ШИВ III мэт, шиг; *бид өнөөдөр тун сүрхий ажиллах шив даа.*

ШИВАТИХ: шиватих цэцэг у р г а м а л дулаан оронд ургадаг нийлмэл цэцгийн язгуурын улбар шар цэцэгтэй ургамал.

ШИВНҮҮЛЭХ шивнэхийн үйлдүүлэх хэв.

ШИВНҮҮР I мал гөрөөсний шийрийн доод дахь бяцхан яс; *шивнүүр яс.*

ШИВНҮҮР II ховч; *шивнүүр зантай хүн.*

ШИВНҮҮР III шивнээ, сөөнгө; *шивнүүр хоолойтой; шивнүүр дуутай.*

ШИВНЭЛДЭХ шивнэхийн үйлдэлдэх хэв.

ШИВНЭХ 1. тодорхой үл сонсдохоор сэм хэлэх; *шивнэж ярих; шивнэж унших; чихэнд нь шивнэх;* 2. хоолой сөөх; *хоолой шивнэчихэв.*

ШИВНЭЭ сөөнгө, үг тодорхойгүй, шивнүүр; *шивнээ хоолой; шивнээ дуу.*

ШИВРҮҮЛЭХ шиврэхийн үйлдүүлэх хэв.

ШИВРЭХ 1. дуслах, шивэргэнэх; *бороо шиврэх;* 2. юмнаас шингэн зүйл шүүрэх, дусагнах; **шүүрэх шиврэх, дусагнах шиврэх** х о р ш.; *шээс шиврэх; ус шиврэх.*

ШИВРЭЭ 1. шивэрсэн нь; **шиврээ бороо** (шивэрч орох бороо); 2. шижин; **шижин шиврээ** х о р ш..

ШИВТЭР шээс шинхэгийн үнэр шүвтэр ч гэдэг; *шивтэр үнэртэй.*

ШИВУУ нэгэн зүйл бөс бараа; *шивуу даавуу.*

ШИВҮҮЛЭХ 1. шивэхийн үйлдүүлэх хэв; 2. шивэгдэх.

ШИВҮҮР юмыг шивж цоолох төмөрлөг багаж; *гутлын шивүүр; сийлбэрийн шивүүр.*

ШИВҮҮРДҮҮЛЭХ шивүүрдэхийн үйлдүүлэх хэв.

ШИВҮҮРДЭХ шивүүрээр шивэх.

ШИВХ малын хат, бууцны шээсэнд дэвтэнгэ баас; **бууц шивх** х о р ш..

ШИВХЛҮҮЛЭХ шивхлэхийн үйлдүүлэх хэв.

ШИВХЛЭХ шивх хийх; *тарианы газрыг шивхлэн бордох.*

ШИВХРҮҮЛЭХ шивхрэхийн үйлдүүлэх хэв.

ШИВХРЭХ 1. олон амьтны цугларч үймэлдэн байгаад тарж цөөрөх, шингэрэх; *кино үзэгчид тарж шивхрэх ойртож байна;* 2. их юмны хорогдон хорогдсоор барагдаж бага болох; *хөрөнгө шивхрэх; ажил шивхрэх.*

ШИВШИГ ичгүүр; **ичгүүр шившиг** хорш.; **шившиг болох** (ичгүүр сонжуурьтай үйл үйлдэж олонд жигшигдэх); **шившиг тарих** (шившигтэй үйл үйлдэх); **шившгээ хутгах** (шившиг тарих).

ШИВШИГТ шившиг бий.

ШИВШИГТЭЙ шившиг бүхий, ичгүүртэй; *шившигтэй явдал; шившигтэй хэрэг үйлдэх.*

ШИВШИХ 1. юман дээр ус шүрших, тургих; *ус шившиж норгох;* 2. хуучирсан хүсэн санаснаа өчиж үлээх; *зоос шивших; шоо шивших;* 3. хүндэтгэвэл зохих хүний сорох татах; *тамхи шивших.*

ШИВШЛЭГ шивших үйлийн нэр.

ШИВШРЭГ явдал золгүй, санаа авхаалж муутай; *шившрэг хүн; шившрэг явдал.*

ШИВШҮҮЛЭХ шившихийн үйлдүүлэх хэв.

ШИВШҮҮР хүндэтгэвэл зохих хүний ганс, соруул.

ШИВЭГНҮҮР шивнүүр, шивнээ.

ШИВЭГЧИН хуучирсан эмэгтэй боол; *зарц шивэгчин.*

ШИВЭЛ: шивэл өвс ургамал иш нарийн, үе охор, хурц ширүүн нэгэн зүйл өвс, яс модыг үрж засч болдог гэдэг.

ШИВЭЛДЭХ шивэл өвсөөр юмыг хавирч зүлгэж хээ сайхан болгох.

ШИВЭР I 1. хүний хөлийн улнаас гарах хөлс; 2. мал гөрөөсний тагалцгийн завсар байдаг жижигхэн булчирхай мэт юм.

ШИВЭР II ургамал 1. царсны төрлийн богино жижигхэн мод; 2. шид жимсний мод; **шивэр бут** (зай завсаргүй ширэлдэж ургасан бут ургамал): **шивэр мод** (няг чигж ургасан мод); **шивэр төлөг** (шивэр ургамлын нэгэн зүйл бут ургамал). • **Шивэр**.

ШИВЭР III: **шивэр авир хийх** сэм шивнэн хэлэлцэх; **шивэр шувар хийх** (шивэр авир хийх); **шивэр шивэр хийх** (хүнд мэдэгдэхгүй, сонсгохгүйгээр сэм шивнэн хэлэлцэх).

ШИВЭР IV цөөн дуслаар алгуур орох бороо; *шивэр бороо; бороо шивэр шивэр орох.*

ШИВЭРГЭЛ хуучирсан эхнэр хүний үсний дүгтүй.

ШИВЭРГЭНЭХ шиврэх, бороо цөөн дуслаар алгуур орох; *бороо шивэргэнэж орох.*

ШИВЭРЛЭХ гавшгайлах, идэвхлэх.

ШИВЭРС ургамал хангайн бүсэнд ургадаг ойм хэлбэртэнд багтах спорт ургамал.

ШИВЭРТҮҮЛЭХ шивэртэхийн үйлдүүлэх хэв.

ШИВЭРТЭХ 1. хүний хөл шивэртэй болох; 2. морины хөлийн бэлбэрхийгээс дор үс сөрч ургах.

ШИВЭХ юмыг зүү шивүүр мэтээр хатгалан цоочих; *гөлөм шивэх; шивж ор мөр гаргах; зүүгээр шивэх.*

ШИВЭЭ (Н) I 1. зарим үет ургамлын урт бөгөөд хурц үр; 2. ургамал нэгэн үет ургамал, мал сайн иднэ, шивээ гарсан цагт малын арьс, амны салст бүрхүүлийг гэмтээх зэргээр хор хүргэдэг.

ШИВЭЭ (Н) II өвс мод зэргийг босгон тогтоож барьсан хашаа хороо мэт юм; **хороо шивээ** хорш..

ШИВЭЭ III: **шивээ хавьс** хүний бэлхүүсний орчин байх охор хавьс.

ШИВЭЭЛҮҮЛЭХ шивээлэхийн үйлдүүлэх хэв.

ШИВЭЭЛЭХ 1. өвс модоор шивээ хороо барих; **шивээлэх хороолох** хорш.; 2. хүн амьтны ойд хоргодон орших; *гөрөөс шивээлэх; Гэмин цэрэг, Тужийн нарсанд шивээлсэн байж билээ.*

ШИВЭЭС шивүүр буюу юмаар шивсэн ором.

ШИВЭЭСЛЭХ шивэх, шивээс гаргах.

ШИВЭЭТ: шивээт хялгана ургамал хялганын төрлийн нэг зүйл ургамал.

ШИВЭЭТЭХ шивээтэй болох; *өвс шивээтэх; мал шивээтэх.*

ШИГ I цагийн хэм, нэг секунд. • **Нэг**

ШИГ II мэт, адил; *өдөр шиг саруулхан шөнө; нар шиг их гэрэлтэй зүйл ховор; бүгд нэг хүн шиг ажиллаж байв; үхэр шиг чулуу шил шиг тунгалаг.*

ШИГ III: **шиг шуг жиг жуг, нам сэм;** *шиг шуг ярилцаж байна билээ.*

ШИГ IV х у у ч и р с а н нэг залангийн харьяаны анги цэрэг, шаг.

ШИГДҮҮЛЭХ шигдэхийн үйлдүүлэх хэв.

ШИГДЭХ 1. юманд гүн орох; *шаварт шигдэх; хүнгарт шигдэх;* 2. юмны дотроос гарахгүй байх; *гэрийн мухарт шигдэх; айлд шигдэх.*

ШИГТГҮҮЛЭХ шигтгэхийн үйлдүүлэх хэв.

ШИГТГҮҮР юмыг шигтгэхэд хэрэглэх хэрэгсэл; *зулын шигтгүүр.*

ШИГТГЭМЭЛ шигтгэж хийсэн юм; *чулуу шигтгэмэл зам.*

ШИГТГЭХ 1. шигдэхэд хүргүүлэх, шигдүүлэх; 2. юмыг юманд суулгаж хатган тогтоох; *зулын гол шигтгэх.*

ШИГТГЭЭ юманд гоёл чимэг болгон шигтгэж хийхэд зориулсан зүйл; *чулуун шигтгээ; шилэн шигтгээ.*

ШИГҮҮ (Н) няг, чигж; **няг шигүү** х о р ш.; *шигүү ой; шигүү нэхээстэй эд; шигүү үстэй арьс.*

ШИГҮҮЛЭХ шигэхийн үйлдүүлэх хэв.

ШИГҮҮХЭН нилээд шигүү, баахан шигүү.

ШИГЧИЙ: шигчий хуруу гар хөлийн тавдугаар хуруу, чигчий ч гэнэ.

ШИГЧИЙЛЭХ шигчлэх.

ШИГЧЛҮҮР шигчлэх хэрэгсэл; *шүдний шигчлүүр.*

ШИГЧЛЭХ 1. шүдний завсар орсон юмыг шигчүүрээр ухаж арилгах, шигчийлэх ч гэнэ; *шүд шигчлэх;* 2. гоочлох, өө сэв эрэх; *чи намайг битгий шигчлээд байгаарай, чадахгүй шүү.*

ШИГЧҮҮР шүдний завсарт орсон юмыг ухаж цэвэрлэх хэрэгсэл, шигчлүүр ч гэнэ.

ШИГШДЭС юмыг шигшихэд гарсан юм; *тарианы шигшдэс; шигшдэс нүүрс.*

ШИГШИГ I хувцасны гурвалжин ба хушуутай оруулга; шигшиг нөхөөс; *шигшиг зүйдэл.*

ШИГШИГ II монгол гэрийн тоононы дөрвөн этгээдээс уях ооcор, мөн гэрийн дээвэр туурганы сэжүүрт уясан ооcор; **ооcор шигшиг** х о р ш..

ШИГШИГДЭЛ шигшигдсэн юм.

ШИГШИГДЭХ шигшихийн үйлдэгдэх хэв.

ШИГШИХ сонгож шилж ялгаруулах; **шилэх шигших** х о р ш.; *шигшиж ялгах; шигшиж авах;* 2. дэвүүр шигшүүрээр юмыг нарийлан ялгах; *тариа шигших; гурил шигших.*

ШИГШҮҮЛЭХ шигшихийн үйлдүүлэх хэв.

ШИГШҮҮР үр тариа, талхалсан нунтагласан зэрэг юмыг агуулж дэвэх зайлах зэргээр хог тоосыг арилгах, нарийныг ялгаруулах хэрэгсэл, зүйл ялгал олон; *гурилын шигшүүр; тарианы шигшүүр; эмийн шигшүүр.*

ШИГЭХ 1. шигдэх; **шигэх шигдэх** х о р ш.: *хэвсэнд шороо шигэх;* 2. шивэх; **шигэх шивэх** х о р ш.; *зүүгээр шигэх; өргөс шигэх.*

ШИД I шивэр модонд ургах нэгэн зүйл жимс, самраас томоохон бөгөөд бөөрөнхий, хатуу хальстай, цөмөөг иднэ, **шид мод** (шид жимсний мод); **шид мөөг** у р г а м а л (шивэр модтой хээр газарт ургадаг, өнгө шаравтархан, маш жижиг нэг зүйл мөөг).

ШИД II рид, ид, хав; **ид шид** х о р ш.; *шидийг олж нисэхийг шахав, шидмэсээр боолгож үхэхийг шахав* о н ь с г о.

ШИДРЭХ 1. хүний зоо авах; 2. яр шарх үгдэрч өвчин эвэршил нэмэгдэх, сэдрэх ч гэдэг.

ШИДРЭЭС шидрэх үйлийн нэр.

ШИДТЭЙ шид бүхий, идтэй, хавтай.

ШИДТЭН шид бүхий этгээд.

ШИДҮҮЛЭХ 1. шидэхийн үйлдүүлэх хэв, чулуудуулах, оёулах; 2. шидэгдэх.

ШИДЭГДЭХ шидэхийн үйлдэгдэх хэв.

ШИДЭМС богино муу дээс; *шидэмсээр боох.*

ШИДЭТ шидтэй; *шидэт амьтан.*

ШИДЭХ I бүдүүвчлэн оёх; **оёх шидэх** х о р ш.; *дээл шидэх.*

ШИДЭХ II таягдах, чулуудах; **шидэх чулуудах** х о р ш.; *чулуугаар шидэх.*

ШИЖИГНҮҮЛЭХ шижигнэхийн үйлдүүлэх хэв.

ШИЖИГНҮҮР түргэн гавшгай, хөдөлгөөнтэй; *шижигнүүр залуу.*

ШИЖИГНЭХ 1. хүн амьтны гэнэт хэлмэж санаа хөдлөн аягүй болох, ширвээтэх; *бие шижигнэх ширвээтэх; дотор шижигнэх;* 2. сэрчигнэх чимээ гарах; *салхи шижигнэх; цас шижигнэх;* 3. шижигнүүр хүний хөдлөх аашлах; *шижигнэсэн ажилчин.*

ШИЖИМ 1. татаж чангаах, уях бэхлэх зэрэгт зориулан бэлтгэсэн оосор; **оосор шижим** хорш.; *хөгнийн шижим; тугалын хүзүүвчний шижим; өвшний шижим;* 2. сэдэв, сэжүүр; *шижмийг олох; сэжүүр шижмийг мэдэх.*

ШИЖИМЛҮҮЛЭХ шижимлэхийн үйлдүүлэх хэв.

ШИЖИМЛЭХ 1. юманд шижим оосор хийх; 2. сэдэв, сэжүүр болох.

ШИЖИМНҮҮЛЭХ шижимнэхийн үйлдүүлэх хэв.

ШИЖИМНЭХ анжис, тэргэнд хөллөсөн морины урдад давхар мал оруулах; *морь шижимнэх.*

ШИЖИМЧ бусдын төлөө догууруар сүлбээлэн зусардаж явах хүн; *шажимч муу хүн.*

ШИЖИМЧЛЭХ шижимч хүний зусар зулгуйч зан байдал гаргаж явах.

ШИЖИН шээс нь савирдаг; *шижин хурга.*

ШИЖИР хамгийн эрхэм цэвэр сайн зүйл; *шижир алт; шижир зоос; шижир мөнгө.*

ШИЖЭЭР зөрүү буруу санаагүй номхон зан чанар.

ШИЖЭЭРГҮЙ ааш авир ширүүн долгин, зан ааль догшин балмад; *шижээргүй ааштай хүн; шижээргүй зантай морь.*

ШИЙ жүжиг; **ший жүжиг, ший бүжиг** хорш.; *ший гарах; шийд гарах; ший тоглох; шийний зарлал;* **ший янгуу** (модон хөл хийж тоглох нэгэн зүйл багт наадам).

ШИЙГУА ургамал хулуугийн язгуурт багтах, янз бөөрөнхийвтөр, амт амтайхан жимс, дотоод нь улаан шар адилгүй.

ШИЙДАМ жанчих зэвсэг, гол төлөв барих этгээд нарийн, үзүүр этгээд бүдүүн байдаг; *модон шийдам; төмөр шийдам.*

ШИЙДАМДАХ шийдмаар цохих жанчих.

ШИЙДАМЛАХ байн байн буюу олны шийдамдах.

ШИЙДВЭР үйл хэргийг гүйцэтгэх тухай тогтсон санаа; **бодлого шийдвэр, тогтоол шийдвэр, тушаал шийдвэр** хорш.: *хурлын шийдвэр; олонхийн шийдвэр; шийдвэр хүлээх; шийдвэр гаргах.*

ШИЙДВЭРГҮЙ 1. үйл хэрэгт шийдвэр гараагүй; *шийдвэргүй ажил хийж үл болно;* 2. хүний үйл хэрэгт шийдэмгий биший нь; *шийдвэргүй дарга;* 3. туушгүй, эрс биш.

ШИЙДВЭРЛҮҮЛЭХ шийдвэрлэхийн үйлдүүлэх хэв.

ШИЙДВЭРЛЭЛ шийдвэрлэх үйлийн нэр.

ШИЙДВЭРЛЭЛГҮЙ шийдгүй.

ШИЙДВЭРЛЭХ 1. шийдвэрлэн тогтоох, шулуудах; *Их хурлын тогтоолыг хэрхэн биелүүлэх тухай шийдвэрлэх хэрэгтэй болоод байна; би хөдөө ажиллахаар шийдвэрлэв; шинжлэх ухааны үүднээс шийдвэрлэвэл зохих зүйл; олонхийн саналаар шийдвэрлэсэн хэрэг;* 2. хамгийн чухалд үзэх; *гуравдугаар таван жилийн төлөвлөгөөний шийдвэрлэх он болж байна; шийдвэрлэх үед няцах.*

ШИЙДВЭРТЭЙ 1. үйл хэрэгт нэгэнт шийдвэр гарсны нь; 2. үйл хэрэгт шууд шийдэмгий, шийдвэр сайтай; *шийдвэртэй хариу өгдөг хүн;* 3. туушгай, эрс, зохистой.

ШИЙДҮҮЛЭХ шийдэхийн үйлдүүлэх хэв.

ШИЙДЭМ шийдам.

ШИЙДЭМГИЙ эрс шийдвэртэй, шийдвэр сайтай; *шийдэмгий ажиллаж гарав.*

ШИЙДЭМГИЙДҮҮ шийдэмгий байдалтай, нилээд шийдэмгий.

ШИЙДЭМГИЙХЭН нилээд шийдэмгий, баахан шийдэмгий.

ШИЙДЭМДҮҮЛЭХ шийдэмдэхийн үйлдүүлэх хэв.

ШИЙДЭМДЭХ шийдмээр цохих жанчих, шийдамдах.

ШИЙДЭХ тогтож шуудрах, шулуудах, шийдвэрлэх; **шийдэх шулуудах, шийдэх шуудрах** хорш.; *би маргааш явахаар шийдэв; ах, хотод суухаар шийдсэн; нэгэнт шийдсэн хүн; шийдсэн хэрэг, үзээд алдана.*

ШИЙР 1. дөрвөн хөлт амьтны нарийн шилбэ яс, таахайг арьстай нь авсныг; *хоол болохын өмнө шийр толгой зугаа;* 2. зарим юмны тусгай **хөл; хөл шийр** хорш.; *бууны шийр; дурангийн шийр;* 3. хүний хөлийг үл тоомсорлон өгүүлэхэд хэрэглэх үг; *шийрээ цааш нь тат;* ☆ **шийр заах** (яс заах, шөрмөс заах).

ШИЙРЛЭХ I 1. юманд шийр хийх, шийртэй болгох; 2. бууг шийр дээр тавьж буудахад бэлтгэх; *цахиур бууг шийрлэж буудав.*

ШИЙРЛЭХ II чийрлах, чийр гаргах.

ШИЙТГҮҮЛЭХ 1. шийтгэхийн үйлдүүлэх хэв; 2. шийтгэгдэх; 3. гүйцэтгүүлэх, хийлгэх; *дагаж шийтгүүлбэл зохих хууль дүрмүүд.*

ШИЙТГЭВЭР 1. шийдвэр; *тушаал шийтгэвэрийг дагах;* 2. шийтгэл, ял **зэмлэл**; *шийтгэвэр хүлээх; ял шийтгэвэргүй.*

ШИЙТГЭГЧ шийтгэл хүлээлгэгч.

ШИЙТГЭЛ ял, торгууль; **ял шийтгэл, торгууль шийтгэл** х о р ш.; *шийтгэл ногдуулах; шийтгэл хүлээх; ял шийтгэл хүлээж яваагүй.*

ШИЙТГЭХ 1. шийтгэл ногдуулах, хүлээлгэх; *хатуу шийтгэх хэрэгтэй; ял хүлээлгэж шийтгэх;* 2. гүйцэтгэх; *дагаж шийтгэх; шүүж шийтгэх; туурвиж шийтгэх.*

ШИЙЧ (ИН) жүжигчин, бүжигчин.

ШИЛ (ЭН) I амьтны хүзүүны ар дагуу байдаг шөрмөс бүлх, мөн түүний орчин газар; *хүзүүний шил идэж болохгүй; шилэн хүзүү; шилээ харах; шилээ маажих;* **шил нь татах** (а. шилний шөрмөс агших; б. дургүй нь хүрэх); **шилий нь харах** (а. үйл ажлын төгсгөлийг үзэх; б. дургүйцсэн юмны холдож зайцах).

ШИЛ II 1. уулын өндөрлөг хянга, уул толгодын арын нам хотос газар; *уулын шил, ар шилээр нь давах; толгойн шил дээр суух харагдана;* 2. ш и л ж с э н зарим сав юмны ар этгээд; *авдрын шил ханзрав; шоголын шил наав; малгайн шил уяв.*

ШИЛ (ЭН) III 1. элсийг хайлуулж хийсэн тунгалаг эд; 2. шилээр хийсэн юм; *шилэн аяга;* **гал шил, галт шил** (юмыг томруулж өсгөдөг шил); **нүдний шил** (хараа муудсанд болон, хараа хамгаалахад зориулж хийсэн хос шил); **гөлмөн шил** (энгээрээ том хэмжээний шил); **цонхны шил** (цонх шиллэх шил); **архины шил** (архи хийдэг шилэн лонх); **чийдэнгийн шил** (цахилгаан гэрлийн шил); **шил архи** (лонх архи); **шил будаг** (паалан); **шил чулуу** (шилний адил тунгалаг нэгэн зүйл чулуу, нүдний шил, чимэг хийхэд хэрэглэнэ); **халууны шил** (хүн амьтны биеийн халууныг хэмжихэд зориулан шилээр бүрж хийсэн хэрэглэл).

ШИЛБҮҮР амьтныг хөөх туухад хэрэглэх зэвсэг; *хурга тугалын шилбүүр.*

ШИЛБҮҮРДҮҮЛЭХ шилбүүрдэхийн үйлдүүлэх хэв.

ШИЛБҮҮРДЭХ шилбүүрээр шавхрах; *хурга шилбүүрдэн хөөв.*

ШИЛБЭ (Н) I 1. хүний шаант чөмөгний нарийн үзүүр тушаа газар; **шилбэний ороолт** (нарийн шилбээр ороох бөс даавуу); 2. амьтны богтос, шаант чөмөгний дор орших нарийн яс; **нарийн шилбэ** (шаант чөмөгний нарийн үзүүр этгээд); **хянгар шилбэ** (шаант чөмөгний хяр яс дагуугийн газар); ☆ **тамхины шилбэ** (татсан цаасан тамхи, янжуурын үлдэгдэл).

ШИЛБЭ II дээл хувцасны товч торгох гогцоо оосор; **товч шилбэ** х о р ш.; *ташааны шилбэ; энгэрийн шилбэ.*

ШИЛБЭ III 1. өвс ургамлын уг иш; *ногооны шилбэ;* 2. цайны доторхи модорхог зүйл; *цайны шилбэ.*

ШИЛБЭ IV: **шар шилбэ** хоёр настай тэмээ.

ШИЛБЭЛЗЭХ муухай зан ааш гаргаж авирлах.

ШИЛГЭЭЛГЭХ шилгээхийн үйлдүүлэх хэв.

ШИЛГЭЭХ 1. морь малын биеэ сэгсэрхийлэх; *морь шилгээх;* 2. хүний хүзүүгээ хөдөлгөн сажих; 3. юмыг сажиж сэгсэрхийлэн хөдөлгөх.

ШИЛДЭГ шилмэл, сонгомол, сонгодог сайн юм; **шилдэг сонгодог** х о р ш.; *шилдэг сайн эд; шилдэг морь; шилдэг тарган шар.*

ШИЛЖИЛТ шилжих үйлийн нэр; *шилжилтийн үе.*

ШИЛЖИХ юмны уг байсан газраасаа өөр тийш буюу нэгээс нөгөөд очих, зайлах, хөдлөх; *ажлаас шилжих; байрнаас шилжих; суринаас шилжих; сургуулиас шилжих; хотоос хөдөөд шилжих.*

ШИЛЖҮҮЛЭГ шилжүүлэх үйлийн нэр; *мөнгөний шилжүүлэг; шилжүүлгээр авна.*

ШИЛЖҮҮЛЭХ шилжихийн үйлдүүлэх хэв; *үйлдвэрийн ажилд шилжүүлэх; багшаар шилжүүлэх.*

ШИЛЛҮҮЛЭХ шиллэхийн үйлдүүлэх хэв, шиллэхэд хүргүүлэх; *цонх шиллүүлэх; авдар шиллүүлэх.*

ШИЛЛЭХ I уулын шилээр явах; *уул шиллэж явах.*

ШИЛЛЭХ II юманд шил тохируулж хийх; *цонх шиллэх; зургийн жааз шиллэх.*

ШИЛЛЭХ III юманд шил хийж бэхлэх; *хайрцаг шиллэх; самбар шиллэх.*

ШИЛМИЙ у р г а м а л иш улаан, навчны үзүүр шуумгай, амт гашуун, үрий нь иддэг нэгэн зүйл ногоо.

ШИЛМҮҮС навчит бус модонд навчны үүрэг гүйцэтгэдэг. зүү хэлбэртэй ногоон сацаг, намиа; *нарсны шилмүүс; гачуурын шилмүүс.*

ШИЛМҮҮСТ шилмүүс бүхий; *шилмүүст мод.*

ШИЛМҮҮСТЭХ модонд шилмүүс ургах.

ШИЛМЭЛ шилдэг, сонгодог, сонгомол юм.

ШИЛРҮҮЛЭХ шилрэхийн үйлдүүлэх хэв.

ШИЛРЭХ ингэ, үнээ зэргийн ботголох тугаллах үед ижил сүргээс салж зайлан явах; *ингэ шилрэх; үнээ шилрэх.*

ШИЛТГЭНЭМ элэгсэг найртай; *шилтгэнэм хайртай.*

ШИЛТГЭНЭХ элэгсэг, найртай зан байдал гаргах.

ШИЛТГЭЭН бэхлэн цогцолж байгуулсан эртний үеийн орд барилга.

ШИЛТЭС: шилтэс мод ганцаар онцгой ургасан мод.

ШИЛТЭХ юмны хөө нясуу хагтаж хатуурах, шүлтэх ч гэдэг; *зуух шилтэх; тогоо шилтэх; данхны дотор шилтэх.*

ШИЛҮҮЛЭХ шилэхийн үйлдүүлэх хэв.

ШИЛҮҮС (ЭН) а м ь т а н мийн язгуурын араатан амьтан, биеийн урт нь 105 см. хүрдэг, сүүл нь 30 см. орчим, агнаж арьсы нь авна.

ШИЛХРЭХ сэлхрэх, цэлхрэх, хүний нүүр этгээд хавдсан мэт хөөнгөтөх.

ШИЛЧ шилээр юм хийх, шил зүсэх мэргэжилтэй хүн.

ШИЛЭЛТ шилсэн нь, сонголт; **шилэлт сонголт** х о р ш.; *шилэлт явуулах.*

ШИЛЭМ огтолж эсгэх юманд оромлож, норгон тавьсан тэмдэг.

ШИЛЭМДЭГ у р г а м а л үрээс нь тос авч, эмэгтэйчүүд үсэндээ түрхэж хэрэглэдэг нэгэн зүйл ногоо.

ШИЛЭМДЭХ 1. юманд шилэм гэмдэг тавих, 2. эд юмыг баахан чийглэх дэвтээх.

ШИЛЭРГЭХ 1. дөжир нөр тэнэж явах; 2. шилрэхэд хүрүүлэх.

ШИЛЭРХҮҮ шил мэт юм.

ШИЛЭРХЭГ шилэрхүү.

ШИЛЭРХЭХ хүний нөр удаан явах.

ШИЛЭХ олон юмны дотроос маш сайныг сонгон авах; **шилэх сонгох** х о р ш.; *хонь шилж суурилах.*

ШИЛЭЭВЭР галыг сэргээж засах хэрэгсэл; *галын шилээвэр.*

ШИЛЭЭГҮҮР шилээвэр.

ШИЛЭЭЛГЭХ шилээхийн үйлдүүлэх хэв.

ШИЛЭЭХ тулга зууханд түлсэн галын үнс цог зэргийг доогуур нь ухаж татаж гаргах; *гал шилээх.*

ШИМ I юмны шүлт шүүс, ашиг, үр тэжээл болох юм; **шим шүүс, шим шүлт, дусал шим, ашиг шим, үр шим шим тэжээл** х о р ш.; **шим татрах** (а. биеийн тамир чадал доройтох; б. өвс ургамлын шүлт муудах; в. саалийн малын сүү буурах, багадах, бага болох); **шимийн архи** (малын сүүний айргаар нэрж гаргасан архи).

ШИМ II: **шим ертөнц** сав III-ын эсрэг утга; ертөнцийн амьтан, ургамал зэрэг амьтай юмс.

ШИМГҮЙ нүмжиг шүлт амтгүй, үр ашиггүй- өл шимгүй юм.

ШИМДҮҮЛЭХ шимдэхийн үйлдүүлэх хэв.

ШИМДЭХ үйл ажилд мэрийх шамдах, чармайх.

ШИМТ амт; **амт шимт** х о р ш..

ШИМТГҮЙ амтгүй; *амт шимтгүй юм байна.*

ШИМТГЭЛ орлогын зүйлээс хууль ёсоор хурааж авах хувь; *цалингийн шимтгэл; татварын шимтгэл; гэгээрлийн шимтгэл.*

ШИМТГЭХ шимтгэл авах; *орлогоос шимтгэх; гааль татвараас шимтгэх; цалингаас шимтгэх.*

ШИМТЭГЛЭЭ ургамал ойт хээр, ойт тайгын бүсэнд голын дагуу, нугаар ургадаг хөх цэнхэр өнгийн цэцэгтэй олон наст ургамал, навчийг цайнд хэрэглэх нь бий.

ШИМТЭЙ шим тэжээл, шүлт нүмжиг сайтай, ашиг орлого ихтэй; *шимтэй ногоо; шимтэй хоол; шимтэй хөрс; шимтэй мал.*

ШИМТЭХ I юманд мэрийж хичээх, чармайх, хүсч дурлах; *ажилдаа шимтэх; тоглоомд шимтэх.*

ШИМТЭХ II юм, юманд нэвтэрч шингэх; *газарт ус шимтэх; хувцсанд тос шимтэх.*

ШИМҮҮЛЭХ шимэхийн үйлдүүлэх хэв.

ШИМХЭХ ялаа батгана, юмны ан завсар эрж орох.

ШИМШИРТЭХ ясны үеэр маш их янгинаж өвдөх.

ШИМШРҮҮЛЭХ шимшрэхийн үйлдүүлэх хэв.

ШИМШРЭХ I хүний бие бага зэрэг шархирах; *бие шимшрэх; зүрх шимшрэх.*

ШИМШРЭХ II эд юм бага сагаар дэмий үрэгдэж хорогдох; *эд хөрөнгө шимшрэх.*

ШИМЭГДЭХ шимэхийн үйлдэгдэх хэв.

ШИМЭЛДЭГ I у р г а м а л мэхээр тарнын язгуурт багтах хүнсний таримал ногоо; сагадай, гурвалжин будаа ч гэнэ.

ШИМЭЛДЭГ II у р г а м а л хээр тал газраар ургадаг, уруул хэлбэртэй цэцэг бүхий олон наст ургамал.

ШИМЭЛДЭГ III өөхийг хайлахад үлдсэн шараг; *өөхний шимэлдэг.*

ШИМЭЛЗЭН а м ь т а н харцгайтай адилхан, өнгө хар бараан, толгойдоо цагаан маханөвөгтэй нэгэн зүйл шувуу.

ШИМЭРГЭН: шимэргэн цас холим цас.

ШИМЭХ сорох; **шимэх сорох** х о р ш.; *хөхөө шимэх; цай шимж уух.*

ШИН I үйрмэг юм хэмжих багтаамжийн хэмжээ, арван битүү.

ШИН II багласан бишгүүр, сэн ч гэдэг.

ШИН III: **шин нугас** а м ь т а н бие чандар цагаан, толгой жигүүр алагчин, хамар дээрээ улаан махан цэцэгтэй нэгэн зүйл шувуу; **шин тахиа** а м ь т а н (тахианы нам, том биетэй, сүүл өргөн, жигүүр богино, хушууны угт махан цэцэгтэй шувуу, зэрлэг тэжээвэр хоёр зүйл бий).

ШИНБАД у р г а м а л янз хушгатай адил, өнгө хүрэн нэг зүйл жимс; **шинбад цэцэг** у р г а м а л (модорхог иштэй, лянхуа цэцгийн адил навчтай нэг зүйл цэцэг).

ШИНГЭВТЭР арай шингэн, баахан шингэн.

ШИНГЭВТЭРХЭН арай шингэвтэр, баахан шингэвтэр.

ШИНГЭДҮҮЛЭХ шингэдэхийн үйлдүүлэх хэв, хэтэрхий шингэн болгох.

ШИНГЭДЭХ 1. хэтэрхий шингэн болох; 2. ус ургамал зэрэг юмны хэтэрхий таруу, сийрэг болох; 3. дууны өнгө дэндүү нарийн болох.

ШИНГЭЛТ шингэх үйлийн нэр; *шингэлт сайтай; шингэлт муутай.*

ШИНГЭЛТТЭЙ шингэлт шингэц сайтай.

ШИНГЭЛҮҮЛЭХ шингэлэхийн үйлдүүлэх хэв, шингэн болгуулах.

ШИНГЭЛЭГ шувуу бялзуухайг хорих тор.

ШИНГЭЛЭХ шингэн болгох; *сүү шингэлэх; цай шингэлэх; эм шингэлэх; шавар шингэлэх.*

ШИНГЭН I. өтгөн гэдгийн эсрэг утга, өтгөн агшуун, нуршингүй, усдасан байдалтайгий нь; *шингэн бодис; шингэн цай; шингэн хоормог;* 2. олон биш цөөн, ягцгүй сийргий нь; *шингэн сахал; шингэн үс; шингэн ой; шингэн ургац;* 3. дууны өнгө нарийн болоод тодорхойгий нь; *шингэн дуу; шингэн хоолой;* ☆ **шингэн мөр үзэх** (шээх).

ШИНГЭРҮҮЛЭХ шингэрэхийн үйлдүүлэх хэв, шингэрэхэд хүргүүлэх.

ШИНГЭРЭХ 1. шингэн болох; *цай шингэрэх; тараг шингэрэх;* 2. цөөрөх, хорогдох; **цөөрөх шингэрэх, хорогдох шингэрэх** х о р ш.: *мод шингэрэх; үс шингэрэх; өвс шингэрэх; хүн шингэрэх;* 3. нарийн болох; *дуу шингэрэх.*

ШИНГЭТГЭХ улам шингэн болгох, шингэрүүлэх.

ШИНГЭТЭХ улмаар шингэн болох, шингэрэх.

ШИНГЭХ 1. ус тос зэргийн юм, юманд нэвтрэн шимтэж орох; *элсэнд ус шингэх; дээлд тос шингэх;* 2. идсэн юмны боловсорч зохицох; *хоол шингэх;* 3. сурч мэдрэх юм, мартагдахгүйгээр тогтож хадаашрах, хоногших; *тархинд нь шингэтэл хэлэх хэрэгтэй;* 4. буслын юм, өөрийн болж эзэмшигдэх; *ашиг болж шингэх;* 5. чацуу хоёр юмыг хавсруулан оеход нэгэн этгээд нь дутуу болох; 6. ш и л ж с э н бүрмөсөн орогнох; *айлд шингэх; харь улсад нэгэнт шингэх;* ☆ **нар шингэх** (нар жаргах, орох); **нэг шингэх эм** (нэг удаа уух хэмжээтэй эм).

ШИНГЭЦ шингэх үйлийн явц; *шингэцтэй; шингэцгүй; шингэц сайтай; шингэц муутай.*

ШИНГЭЭХ шингэхийн үйлдүүлэх хэв, шингэхэд хүргүүлэх.

ШИНЕЛЬ цэргийн хүний нэг зүйл дүрэмт дээл; *шинель өмсөх; шинель тайлах.*

ШИНЖ чанар, байдал, дүр, төлөв; **шинж чанар, шинж байдал, овор шинж, шинж төлөв, дүр шинж, шинж тэмдэг** х о р ш.; *шинж сайтай; шинж муутай.*

ШИНЖГҮЙ 1. хүний зан санаа, ханилгаа чанар муутай; *шинжгүй амьтан;* 2. харамч.

ШИНЖИГЧ 1. шинжич; 2. шинжээч.

ШИНЖИЛГЭЭ (Н) 1. судалгаа; *хээрийн шинжилгээ; химийн шинжилгээ; шинжилгээний анги: эрдэм шинжилгээний ажилтан;* 2. аливаа юмны бүтцийг тодорхойлох судалгаа; *цусны шинжилгээ хийлгэх; эмнэлэгт хэвтэж шинжилгээ хийлгэх.*

ШИНЖИЛЦГЭЭХ олноороо шинжлэх.

ШИНЖИХ 1. шинжлэх; *аршаан ус шинжжих;* 2. сүсэг бишрэлийн үүднээс хүний хувь учралыг зөгнөх.

ШИНЖИЧ сүсэг бишрэлийн үүднээс хүний ирээдүйн хувь учралыг зөгнөгч.

ШИНЖЛҮҮЛЭХ 1. шинжлэхийн үйлдүүлэх хэв; 2. шинжлэгдэх.

ШИНЖЛЭГЧ эрдэм шинжилгээний судалгаа хийгч, судлалч; *нуурын давсны бүтцийг шинжлэгч.*

ШИНЖЛЭЛ судлал; **шинжлэл судлал** х о р ш..

ШИНЖЛЭХ судлах; **шинжлэх судлах** х о р ш.; *байгалийн хууль зүйг шинжлэх; нийгмийн хөгжлийн хуулиудыг шинжлэн судлах; уурхайн баялгийг шинжлэн судлах;* **шинжлэх ухаан** (байгаль, нийгэм, сэтгэхүйн хөгжлийн зүй тогтоолыг судлах сургаалуудын тогтолцоо); **шинжлэх ухааны академи** (эрдэм шинжилгээний ажлыг удирдах дээд байгууллага; *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх ухааны Академи).*

ШИНЖҮҮЛЭХ шинжихийн үйлдүүлэх хэв.

ШИНЖЭЭЧ (ИН) шинжлэгч.

ШИНХЭГ 1. шээс зэргийн шивтэр үнэр; **шинхэг шивтэр** х о р ш.; 2. шувууны охор сүүлд нь байдаг өмхий булчирхай.

ШИНШ овор, дүр; **овор шинш** х о р ш..

ШИНШИГЧ х у у ч и р с а н цаг уурын байдлыг шинжлэх хүн.

ШИНШИХ юм үнэрлэх; *нохой шинших;* **хүн хэрэглэхгүй, нохой шиншихгүй** юм (ямар ч хэрэггүй юм).

ШИНШЛҮҮЛЭХ шиншлэхийн үйлдүүлэх хэв.

ШИНШЛЭХ байн байн шиншлэх; *нохой шиншлэн явав*

ШИНШҮҮЛЭХ шиншихийн үйлдүүлэх хэв.

ШИНЭ хуучин гэдгийн эсрэг утга, сая гарсан, ирсэн, хийсэн, удаж хуучраагүй юм; *шинэ гэр; шинэ барилга; шинэ хот; шинэ дээл; шинэ техник; шинэ үе; шинэ ном; шинэ ажил; шинэ мах; шинэ бэр яарахад ширмэн тогоо үл халах* з ү й р; **шинэ цэрэг** (цэрэгт ирээд удаагүй цэрэг): **шинэ санаачлага** (аливаа үйл ажилд дэвшилттэй шинэ зарчим, арга ажиллагааг сүвэгчлэн бодсон санаачлага); **шинийг санаачлагч** (шинэ санаачлага гаргагч); шинэ жил); (сая гарсан жил); **шинэ сар** (сая гарсан сар); **шинийн нэгэн** (сар бүрийн анхны өдөр).

ШИНЭВТЭР баахан шинэ, арай шинэ.

ШИНЭД сарын эхний хоногууд; *хоёрдугаар сарын шинэдээр ажлаа дуусна.*

ШИНЭДЭХ хэтэрхий шинийн учир тохиромжгүй болох.

ШИНЭЛҮҮЛЭХ шинэлэхийн үйлдүүлэх хэв.

ШИНЭЛЭХ 1. шинэ жил гарч баярын ёс хийх; **шинэлэх цагаалах** х о р ш.; *сар шинэд сайхан шинэлэв үү?* 2. шинэ болгох; шинэчлэх.

ШИНЭС у р г а м а л хангайн ой тайгад ургадаг нэг зүйл шилмүүст мод, харгай ч гэдэг.

ШИНЭСГЭХ шинэсэхийн үйлдүүлэх хэв, шинэ болгох.

ШИНЭСЭХ улам шинэ болох.

ШИНЭТГЭЛ шинэтгэх үйлийн нэр: ☆ **шинэтгэл өдөр** (сарны зурхайн ёсны сарын эхэн өдөр).

ШИНЭТГЭХ хуучныг халж шинэ болгох.

ШИНЭТЭХ улам шинэ болох.

ШИНЭХЭН шинэ, баахан шинэ; *шинэхэн түүх* (ойрхи үеийн түүх); **нэн шинэхэн түүх** (нэн ойрхи үеийн түүх).

ШИНЭЧ шинийг санаачлагч

ШИНЭЧЛҮҮЛЭХ шинэчлэхийн үйлдүүлэх хэв.

ШИНЭЧЛЭЛ аливаа юмыг сайжруулахын тулд өөрчлөн шинэчлэх шинэтгэл; *шинэчлэл хийх.*

ШИНЭЧЛЭХ юмыг шинэ болгох, өөрчлөх; *шинэчлэн засах; шинэчлэн тоноглох;* 2. шинийг ялгаж авах.

ШИР (ЭН) I үхэр адуу тэмээ, тураг гөрөөс зэргийн арьс; **арьс шир** х о р ш.; *арьс ширний завод.*

ШИР II 1. шороон будаг; 2. модон сав хэрэглэлд түрхэж өнгө гаргах маажин мэт нэгэн зүйл тусгай будаг.

ШИР III **өр шир** өглөгийн зүйл; *тэр бааxан өр ширтэй хүн гэдэг; өртэй ширтэй байх нь өөрт муу.*

ШИР IV: **шир шир хийх** бороо орох, цасан дээр гишгэх зэрэгт дуугарах чимээ сэрэгдэх; **шир шор хийх** (салхинд модны навч шилмүүс өвсний толгой зэргийн юмны дуугарах чимээ сэрэгдэх); **шир шир орох** (борооны өчүүхэн өчүүхэн ширжигнэн орох).

ШИРВҮҮЛ юм ширвэхэд зориулж хийсэн хэрэглэл, ихэвчлэн хялгас буюу үхэр адууны сүүлээр хийнэ; *ялаа батганын ширвүүл; хог тосны ширвүүл.*

ШИРВҮҮЛЭХ 1. ширвэхийн үйлдүүлэх хэв; 2. ширвэгдэх.

ШИРВЭГДЭХ ширвэхийн үйлдэгдэх хэв.

ШИРВЭГНҮҮЛЭХ ширвэгнэхийн үйлдүүлэх хэв.

ШИРВЭГНЭХ 1. бороо цас зэргийн алгуур зөөлөн орох; *бороо ширвэгнэн орох;* 2. салхины сэрвэлзэж салхилах; *ширвэгнэн салхилах;* 3. өвс мод зэргийн салхинд хөдлөх; *өвс ширвэгнэх;* 4. галд түлсэн нарийн жижиг зүйл түргэн ноцож дуусах; *ширвэгнэж ноцох;* 5. нүдний цэцгий тогтууригүй нааш цааш байн байн хөдлөх; *нүд ширвэгнэх.*

ШИРВЭЛЗҮҮЛЭХ ширвэлзэхийн үйлдүүлэх хэв.

ШИРВЭЛЗЭХ 1. ширвэгнэх; 2. байн байн ширвэх.

ШИРВЭХ 1. юмаар сажиж цохих цавчих; *уургаар ширвэх; сэлмээр ширвэх;* 2. юмаар сажилхийлах; *ханцуйгаар ширвэх; гүвүүрээр ширвэх;* 3. шүүрдэх, туужуудах; *хог ширвэх; туужуугаар ширвэх;* 4. бусдыг нүдний гаар харж цааш хамдах; *ширвэж харах; нүдээрээ ширвэх.*

ШИРВЭЭ 1. жирвэгэр нарийн юм; *ширвээ хар сахалтай, ширүүн хурц харцтай, сүрхий сайн эр байж гэнэ;* 2. модны унанги салаа мөчир; *ойгоос ширвээ түүж түлдэг.*

ШИРВЭЭДҮҮЛЭХ ширвээдэхийн үйлдүүлэх хэв.

ШИРВЭЭДЭХ өегдөх, бээрч доройтох; *хүйтэнд төлөг ширвээдэх.*

ШИРВЭЭТЭХ 1. айн халширч, сэтгэл хирдхийн бие арзасхийх; 2. өвдөх, даарах зэргээс бие арзганан аягүй болох.

ШИРГЭХ 1. шингэн юм халж уур болон хатсаар хорох ба үгүй болох; *булаг ширгэх; горхи ширгэх; цай ширгэтэл буцалгах;* 2. малын сүү шим татарч хорох ба багасах, үгүй болж зогсох; *хонь ширгэх; ингэ ширгэх;* 3. амьтны нүд хонхойж ёнхойн турах, хатах төлөвтэй болох; *нүд нь ширгэх; ухархай нь ширгэх.*

ШИРГЭЭЛГЭХ ширгээхийн үйлдүүлэх хэв, ширгээхэд хүргүүлэх .

ШИРГЭЭХ 1. ширгэхэд хүргүүлэх; 2. удтал буцалгах; *ус ширгээх; цай ширгээх;* 3. бууны овоо хараар онох юмнаас доошлуулж шагаах; *буу ширгээх; ширгээж буудах.*

ШИРДҮҮЛЭХ ширдэхийн үйлдүүлэх хэв, шир будгаар будуулах.

ШИРДЭГ дэвсгэр, бамбай; *ширмэл ширдэг; орны ширдэг; хом ширдэг.*

ШИРДЭХ 1. будгаар будах; 2. шир маажингаар будах.

ШИРЛҮҮЛЭХ ширлэхийн үйлдүүлэх хэв.

ШИРЛЭХ юмыг ширээр боож бэхлэх; *авдар ширлэх; хэнгэрэг ширлэх.*

ШИРМЭГЛҮҮЛЭХ ширмэглэхийн үйлдүүлэх хэв.

ШИРМЭГЛЭХ ширэх, товшиж оёх.

ШИРМЭЛ I ширж оёсон юм; *ширмэл ширдэг: ширмэл ул.*

ШИРМЭЛ II улайтгаж, давтах зэргээр хатуужуулсан төмөр.

ШИРТВЭЛЗЭХ 1. хялбалзан харах; 2. морь малын явахдаа ийш тийш хялмалзан харах.

ШИРТҮҮЛЭХ ширтэхийн үйлдүүлэх хэв.

ШИРТЭЛХИЙЛЭХ байн байн ширтэх.

ШИРТЭХ юмыг эрслэн анхаарч ажиж үзэх; **ажих ширтэх** х о р ш.; *ширтэн харах; алс ширтэн суув.*

ШИРҮҮДҮҮЛЭХ ширүүдэхийн үйлдүүлэх хэв.

ШИРҮҮДЭХ 1. хэтэрхий ширүүн болох; 2. ш и л ж с э н зан авир хэтэрхий догшдох.

ШИРҮҮЛҮҮЛЭХ ширүүлэхийн үйлдүүлэх хэв.

ШИРҮҮЛЭХ I ширэхийн үйлдүүлэх хэв.

ШИРҮҮЛЭХ II 1. ширүүн зан ааш гаргах; 2. салхи шуурга, бороо цасны хүч нэмэгдэх түргэлэх зэргээр ширүүсэх; 3. түргэлэн явах; *морио гуядаж ширүүлэн хатирав.*

ШИРҮҮН зөөлөн гэдгийн эсрэг утга; 1. юмны зөөлөн илбэрүүгүй; **хатуу ширүүн** х о р ш.; *ширүүн үс; ширүүн даавуу;* **ширүүн билүү** (хатуу билүү, гуранз); 2. морь малын зан авир хурц дөлгөөн; **хурц ширүүн** х о р ш.; *ширүүн морь;* 3. ш и л ж с э н хүний үг, зан байдал догшин хатуу: **ширүүн догшин** х о р ш.; *ширүүн хүн;* **ширүүн үг** (зандрах дайрах хатуу үг); **ширүүн зан** (догшин зан).

ШИРҮҮСГЭХ ширүүсэхийн үйлдүүлэх хэв.

ШИРҮҮСЭХ улмаар ширүүн болох.

ШИРҮҮТГЭХ ширүүтэхэд хүргүүлэх, ширүүн болгох.

ШИРҮҮТЭХ улам ширүүн болох, ширүүсэх.

ШИРХ I а м ь т а н үхширсэн бууцнаас төрж малд орж малыг зутраадаг хорхой, шар ширх хөх ширх гэж ялгал бий.

ШИРХ II 1. мод ургамлын газарт нягт шахцалдан ургасны нь; *ширх ургац;* 2. амьтны үсний өтгөн няг; *ширх үстэй;* 3. эд бөсний нэхээс чигж сайн; *ширх нэхээс;* 4. арьс ширний хөрс хатуу нягт; *ширх хөрстэй арьс.*

ШИРХРЭХ унжирч өвдөх; *гар ширхрэх; булчин ширхрэх.*

ШИРХТҮҮЛЭХ ширхтэхийн үйлдүүлэх хэв; *мал ширхтүүлэх.*

ШИРХТЭХ бууц, мал ширх хорхойтой болох.

ШИРХЭГ 1. юмны нэг нэгээр саланги хэсэг; *нэг ширхэг утас; нэг ширхэг үс; нэг ширхэг өвс; бухал өвсний ширхэг зүү эрж олохын хир бэрхшээлтэй;* 2. үргэлж юмны тус тус салж болмоор байдлы нь; *модны ширхэг; махны ширхэг; чулууны ширхэг;* **ширхэг ч байхгүй** (ганц ч байхгүй, юу ч байхгүй).

ШИРЧ (ИН) 1. будах мэрэгжилтэй хүн; 2. шир эдлэлийг боловсруулах мэрэгжилтэй хүн.

ШИРЧИГ: ширчиг ширчиг хийх юмны шажигнан шижигнэн дуугарах чимээ гарах.

ШИРЧИГНҮҮЛЭХ ширчигнэхийн үйлдүүлэх хэв.

ШИРЧИГНЭХ ширчиг ширчиг гэсэн чимээ гарах.

ШИРЭГ зүлэг; **зүлэг ширэг** х о р ш.; *ширэг суулгах.*

ШИРЭЛДҮҮЛЭХ ширэлдэхийн үйлдүүлэх хэв.

ШИРЭЛДЭХ үс зэрэг зүйл бөөгнөлдөн даахирах; *гээгэг ширэлдэх; морины дэл ширэлдэх.*

ШИРЭМ (ШИРМЭН) 1. төмрийн хүдрийн хайлмал, ганг бодвол хэврэг бөгөөд хялбар давтагдах чанартай; 2. мөн зүйлээр хийсэн эдлэл; *ширмэн тогоо; зуухны ширэм; ширмийн үйлдвэр; ширэм хайлалт;* **ширмэн жанчуур** (газар дагтаршуулах хэрэгсэл).

ШИРЭМШИХ юмны салхинд дэлсэгдэн хатуурах; *цас ширэмших; үнс ширэмших.*

ШИРЭНГЭ (Н) ойн доторхи ягц ургасан нарийн мод; *ширэнгэд орж төөрөлдөв.*

ШИРЭХ I юмыг утсаар бат түжир болгон сёх; *ширдэг ширэх; ул ширэх.*

ШИРЭХ II ширэм буюу хэсэг жижиг төмрийг хайлуулж бөөн үргэлж болгон найралдуулах; *төмөр ширэх; болд ширэх.*

ШИРЭЭ (Н) I 1. юм хум агуулах тавих гавцантай, хэвтээ хэлбэртэй сав хэрэглэл, хэлбэр байдал зүйл ялгал олон; *бичгийн ширээ; аяганы ширээ; хоолны ширээ; дугуй ширээ;* **ширээ засах** (ширээн дээр хоол зуушны зүйл засч бэлтгэх); **ширээ авах** (ширээн дээр засч бэлтгэсэн хоол зуушны зүйлийг худалдан авч хэрэглэх); **ширээний дэн** (ширээн дээр тавьж гэрэлтүүлэх дэн); **ширээний бүтээлэг** (ширээг бүтээх бүтээлэг); 2. хаан хүн, төр ёслолын үед суух сандал; **хаан ширээнд суух** (хаан болох): **ширээ булаацалдах** (албан тушаалд ахихыг оролдох.

ШИРЭЭ II гэмээний бөх эгц босоогий нь; *ширээ бөхтэй тэмээ.*

ШИРЭЭЛДЭХ хүн амьтны биеэ тэнцүүлэн, хөлөө тулгуурлаж яг зогсох; *ширэлдэж зогсох.*

ШИРЭЭЛЭХ I тэмээний бөх ширээ болох.

ШИРЭЭЛЭХ II хүүрийг ширээ дээр тавих.

ШИРЭЭС ширсэн оёдол; *ширээс сайтай ширдэг.*

ШИРЭЭХ төмрийг улайтгаж, давтах зэргээр хатуужуулах, хатуу болгох, ширэх ч гэдэг; *төмөр ширээх.*

ШИХ: ших мах хүний шүдний завсрын мах.

ШИХЭН өчүүхэн; **өчүүхэн шихэн** х о р ш.. .

ШИХЭР чихэр.

ШИШ у р г а м а л гойд **тэсвэртэй тэжээлийн**, нэг наст ургамал, чанараараа эрдэнэ шиштэй бараг адил, хатаах даршлах зэргээр хэрэглэнэ, жугар ч гэдэг; **эрдэнэ шиш** у р г а м а л (том навчтай, өндөр ургадаг, боргоцойд хуралдан ургасан шар өнгийн үр бүхий ургамал, үрийг боловсруулж хүн идэхээс гадна малд сайн тэжээл болно; *эрдэнэ шиш тариx; эрдэнэ шишийн гурил; эрдэнэ шишийн дарш);* **хэрчмэл шиш** (хэрчсэн гурил); **татмал шиш** (мянтууз); **өлгөмөл шиш** (гоймон).

ШОВ сумны тусах нисэх, шингэн юмны дуслах зэргээс гарах чимээ; *шов хийх; шов шов хийх.*

ШОВГОНОХ шовгор юмны шовго шовго хөдлөх.

ШОВГОНУУЛАХ шовгонохын **үйлдүүлэх** хэв.

ШОВГОР өндөр босоо хэлбэртэй шовхгор юм; **гозгор шовгор** х о р ш.; *шовгор уул; шовгор оройтой малгай.*

ШОВИНИЗМ арьс өнгөөр ялгаварлах, үндэстнүүдийг хооронд нь дайсагнуулах, тэднийг үзэн ядах сургаалыг номлогч хөрөнгөтний үндэсний үзэл.

ШОВИНИСТ шовинизмийг баримтлагч.

ШОВИР: шовир шүвэр хийх сэмээр нууцлан хэлэлцэх; *шовир шүвэр ярилцах.*

ШОВОЙЛГОХ шовойхын үйлдүүлэх хэв.

ШОВОЙХ шовгор болох.

ШОВОЛЗОХ шовгор юмны шовос шовос хөдлөх.

ШОВОЛЗУУЛАХ шоволзохын үйлдүүлэх хэв.

ШОВХ юмны үзүүр нарийн хурц; *шовх зүү; шовх үзүүртэй хутга; шовх хад; шовх хамар;* ☆ **шовхоо үзэх** (тоглоомд хайнцаад шийдвэрлэх тоглолт дахин хийж, хожих хожигдохоо үзэх).

ШОВХГОР 1. шовх; 2. юмны дээд этгээд буюу үзүүр шовгор шувтан хэлбэртэйгий нь.

ШОВХИЙХ 1. шов гэсэн чимээ хаяа гарах; **шов шов хийх** (шов гэсэн чимээ байн байн гарах); 2. буздыг озож үнсэх; *шовхийтэл үнсэх;* 3. хүүхэд багачууд эхийнхээ хөхийг түргэн зуур хөхөх; *хөхөө шовхийх.*

ШОВХЛОХ 1. шовх болгох; *харандааны үзүүр шовхлох;* 2. шовхоо авах.

ШОВХЛУУЛАХ шовхлохын үйлдүүлэх хэв.

ШОВХОЙЛГОХ шовхойход хүргүүлэх

ШОВХОЙХ шовойх, шовхгор болох.

ШОВШГОР: шовшгор нохой хушуу хоншоор урт нохой.

ШОВШУУР I гөрөөс агнахад уриадах хэрэгсэл, үйсээр хийнэ; *шовшуур уриа.*

ШОВШУУР II а м ь т а н уул ойд оршино, шөнө дуугарна, өдөр авсаар олдохгүй нэгэн зүйл шувуу.

ШОВШУУРДАХ шовшуур уриа дуугаргах.

ШОВШУУРДУУЛАХ шовшуурдахын үйлдүүлэх хэв.

ШОВШУУРЛАХ шовшуур шувууны дуугарах.

ШОГ бусдыг **шоглосон**, шогчилсон юм; *шог хүн; шог хүүхэд;* **шог зураг** (үнэн дүрээс хэтрүүлэн, шүүмжилж шоглон зурсан зураг); **шог гараа** (нийгмийн дутагдлын тодорхой нэгэн зүйлийг онцлон авч бага цагийн дотор жүжиглэн шоглох нэг хэлбэр): **шог найруулал** (дутагдалтай үйл явдлуудыг шүүмжлэн шоглож бичсэн найруулал).

ШОГЛОХ 1. бусдыг зүгээр байлгахгүй, хэлж өдөөх; **шоолох шоглох** х о р ш.; *хүүхэд битгий шоглоод байгаарай;* 2. бусдад битүү далдуур хор хөнөөл хүргэх зоволх.

ШОГЛУУЛАХ шоглохын үйлдүүлэх хэв.

ШОГТОЙ шог бүхий; *шогтой хүүхэд.*

ШОГЧ шоглох зантай хүн; *шогч хүн; шогч хүүхэд.*

ШОГШГОЙ модны боргоцой тоорцог; *харгай модны шогшгой; самрын шогшгой.*

ШОГШИГО шошго.

ШОГШИЙХ ихээр зан байдал гарган суух.

ШОГШИХ I 1. морь малын хатир сэглэгт хүрэхгүй шогшоо явдлаар явах; 2. хүний алхахаас түргэхэн, гүйхээс удаахан явах.

ШОГШИХ II дуу гарч чадахгүй бүгтрэн уйлах; *шогшин уйлах.*

ШОГШИХ III тараг айраг зэргийн ихэд исч шог шог хийж сагах; *тараг шогших.*

ШОГШОО I морь малын алхмаас түргэхэн, хатирахаас бага шог шог хийж явах явдал.

ШОГШОО II ерийн, халдваргүй хөнгөн хавиад; *шогшоо ханиад; нусгай шогшоо.*

ШОГШРОХ сонирхох, харамсах зэрэгт хэлээ тагнайд наалдуулан салгаж шог шог дуугарах; тагнай танших ч гэдэг.

ШОГШРУУЛАХ шогшрохын үйлдүүлэх хэв.

ШОГШУУЛАХ шогшихын үйлдүүлэх хэв, шогшиход хүргүүлэх.

ШОДГОНОХ шодгор юмны шодго шодго хөдлөх.

ШОДГОНУУЛАХ шодгонохын үйлдүүлэх хэв.

ШОДГОР шодон, годгор; **годгор шодгор** х о р ш.; *шодгор сүүл; шодгор гэзэг.*

ШОДОЙЛГОХ шодойход хүргүүлэх.

ШОДОЙХ шодон, шодгор болох.

ШОДОЛЗОХ шодгор юмны шодос шодос хөдлөх.

ШОДОЛЗУУЛАХ шодолзохын үйлдүүлэх хэв.

ШОДОН богино нарийн, годгор; **годон шодон** х о р ш.; *шодон гэзэгтэй хүн; шодон сүүлтэй морь.*

ШОДОХ үл хүрэлцэх, үл тохирох зүйлийг хувааж ногдуулах зэрэгт шоо орхих буюу сугалаа хийж хуваах, ногдуулах; **шодох сугалах х о р ш.**

ШОДУУЛАХ шодохын үйлдүүлэх хэв.

ШОЖГОР зан байдал хэвлүүн.

ШОЖИГНОХ шингэн юмны гоожих урсах зэрэгт шор шор чимээ гарах.

ШОЖИГНУУЛАХ шожигнохын үйлдүүлэх хэв.

ШОЖИЙХ шожгор зан байдал гаргах.

ШОЛ: шол шол хийх юмнаас гоожиж дуссаны чимээ сонсдох.

ШОЛБОГОР 1. амьтны бие хунхгүй сул байдалтай; *шолбогор биетэй хүүхэд; царай нь шолбогор байна;* 2. яс чанар сул муухан юм; *шолбогор муу эд.*

ШОЛБОЙЛГОХ шолбойход хүргүүлэх.

ШОЛБОЙХ 1. шолбогор болох; 2. хөлдүү юмны гэсч нялцайх; *мах шолбойтол гэсэх;* 3. норох; *шолбойтол нэвтрэв.*

ШОЛХГОР шолбогор, шалхгар байдалтай юм.

ШОЛХОЙХ шолхгор болох, шалхайх.

ШОЛЧГОР шалчгар, барагтайхан.

ШОЛЧИЙХ шалчийх, жалжийх.

ШОМБОГОНОХ шомбогор юмны шомбого шомбого хөдлөх.

ШОМБОГОНУУЛАХ шомбогонохын үйлдүүлэх хэв.

ШОМБОГОР шомбон, цомбон, цомбогор.

ШОМБОЙХ шомбогор байдалтай болох.

ШОМБОЛЗОХ шомбогор юмны шомбос шомбос хөдлөх.

ШОМБОЛЗУУЛАХ шомболзохын үйлдүүлэх хэв.

ШОМБОН жижиг шомбогор хэлбэртэй юм, цомбон, цомбогор; *шомбон толгой; шомбон шаазан; шомбон лонх.*

ШОМГОР юмны шим шүүс хатах буюу гүйцэд сайн болоосорч чадалгүй хорчгор харчгар болсны нь; *шомгор үр; шомгор самар*

ШОМОЙХ шомгор байдалтай болох.

ШОН 1. босгосон мод; *утасны шон босгох;* 2. морь мал уях хэц зэл бүхий босгосон мод, уяа, хондого ч гэж бас нэрлэнэ.

ШОНГҮЙ 1. бусдын үгэнд хариу үг хэлж огт чадахгүй; 2. нохойн огт хуцахгүйгий нь; 3. горигүй.

ШОНТГОР өндөрхөн шовгор буюу шантгар хэлбэртэй юм; *шонтгор хамар; шонтгор эвэр; шонтгор хамартай гутал.*

ШОНТОЙЛГОХ шонтойход хүрүүлэх.

ШОНТОЙХ шонтгор болох.

ШОНХГОР шонхор II.

ШОНХОГНОХ шонхгор юмны шонхог шонхог хэдлэх.

ШОНХОЛЗОХ шонхгор юмны хөдлөх.

ШОНХОР I а м ь т а н өдрийн махчин шувуун: язгуурт багтдаг шувуу, дэлхий дээр тархмал, бүгд найман төрөлд хуваагдана; **шонхор зөгий** а м ь т а н (биеийн урт нь 0,5—5 см. эмийн гэдэс урт, өөрийн авгалдайг бусад шавьж болон аалзанд цацна, хөдөө аж ахуй ба ойн аж ахуйн хортон шавьжийг устгадаг ашигтай шавьж); **шонхор хөхтрүү а м ь т а н** (хөхтүрүүтэй адил бөгөөд уртхан, дундуураа нарийн, ялааг барьж иддэг нэгэн зүйл шавьж).

ШОНХОР II хүний шовх өндөр хамартайгий нь; *шонхор хамартай.*

ШОО I 1. дөв дөрвөлжин, маш дөрвөлжин; *шоо дөрвөлжин; нэг шоо дөрвөлжин сантиметр;* 2. мэрэглэх, наадах зэрэгт хэрэглэх 1-ээс 6 хүртэл нүхтэй дөв дөрвөлжин зүйл; **шоо орхих** (шоог гартаа атгаж байгаад хаях); **шоо наадах** (нэг зүйл тоглоом, шоог орхиж дээш харсан нүхний тоогоор уралдан явж байр эзлэн наадна).

ШОО II: **шоо буга** а м ь т а н бие бяцхан, өнгө улааврхан нэг зүйл буга.

ШОО III: **шоо гуа** у р г а м а л амтайхан гуатай адилавтар бөгөөд арай уртхан нэг зүйл гуа.

ШОО IV: **шоо ооль** модыг халин цавчих багаж, гар ооливс том, шуу ч гэнэ, хөл ооль ч гэнэ.

ШООВИН буудайн гурилд чихэр, ус хоршиж хушганы цөмийн идээ хийж тосонд хайрсан нэгэн зүйл идээ, нимгэн шоовин ч гэнэ.

ШООВДОР ад үзэгдсэн амьтан; *шооводор хүүхэд; шооводор нохой.*

ШООВДОРЛОХ ад шоод болгон үзэх.

ШООВДОРЛУУЛАХ шоовдорлохын үйлдүүлэх хэв.

ШООВОР бие бяцхан нэгэн зүйл барс.

ШООД: ад шоод, элэг шоод ад, доог; *ад шоод болох.*

ШООДВОР шоовдор.

ШООДВОРЛОХ шоовдорлох.

ШООДВОРЛУУЛАХ шоовдорлуулах.

ШООДОЛТОЙ шоодвол зохих зүйл бүхий; *шоодолтой этгээд; шоодолтой хэрэг.*

ШООДОХ I шоо хаяж мэрэглэх.

ШООДОХ II ад шоод үзэх, шоовдорлох.

ШООЛОГДОХ шоолохын үйлдэгдэх хэв.

ШООЛОХ бусдыг хочлох, дооглох элэглэх зэргээр муу муухайд үзэх, шоодворлох; **шоолох шогчлох** х о р ш..

ШООР у р г а м а л буурцагт ургамлын язгуурт багтах нэг наст өвсөрхөг ургамал, цэцгийн өнгө хөх, малд сайн тэжээлтэй, туулайн тагнай ч гэдэг.

ШООРОН гозгор шоргор юм; *шоорон эвэртэй цагаан ямаа.*

ШООРТОЙ 1. хэрүүлд халдамхай зантай; 2. самуу явдалтай хүн.

ШООХГОР цээж этгээд нарийн шовгордуу байдалтай.

ШООХОЙХ шоохгор болох.

ШООЧ I бусдыг шоолох зантай хүн.

ШООЧ II шоо орхиж мэрэглэх хүн.

ШОР I илдээс шудрага, хоёр этгээдэд иртэй том хутга мэт зэвсэг.

ШОР II 1. юм хумыг хатгах сүлбэхэд хэрэглэх зүйл; *махны шор; ухах шор; малын хамар цоолох шор;* 2. юмны нарийн хурц, шовх үзүүрий нь.

ШОР III зургаан амттаны доторхи давсны амт мэт амт, шорвог ч гэдэг.

ШОРВИЙХ шорвигор болох.

ШОРВИГОР сахал үсний шөрвийсөн нь.

ШОРВОГ 1. давс хужрын мэт амт; 2. хоол ундны давс ихдэсний нь; *шорвог амттай хоол.*

ШОРВОГДОХ хэтэрхий шорвог болох.

ШОРВОГДУУЛАХ шорвогдохын үйлдүүлэх хэв.

ШОРВОЙХ ус өд бүхий юмны шөрвийх; **шөрвийх шорвойх** х о р ш.

ШОРГООЛЖ (ИН) а м ь т а н биеийн дундуур нарийн, газарт нүх хийж орших шавьж, төрөл зүйл олон; *шоргоолжны үүр; алаг шоргоолж; хар шоргоолж;* **шоргоолжин чоно** а м ь т а н (дутуу шүдэтийн язгуурын хөхөөр өсөх амьтан, толгой ба хушуу урт шөмбөгөр, хэл урт, шүдгүй, шоргоолж идэх, төрөл зүйл олон).

ШОРДОХ I шороор хатгах сүлбэх.

ШОРДОХ II тэмээ тэргээр аялан явахад ачааг тэргүүлэн хөтөлж зам удирдан явах.

ШОРЖИГНОХ юмнаас шор шор гэсэн чимээ сонсдох.

ШОРЖИГНУУЛАХ шоржигнохын үйлдүүлэх хэв.

ШОРЛОХ 1. юмыг шороор хатгах; *мах шорлох;* 2. юмны үзүүрийг хурц шөвгөр болгох.

ШОРЛУУЛАХ шорлохын үйлдүүлэх хэв.

ШОРНО у р г а м а л сахал өвснөөс өндөр, навч хавтгай, хээр ургадаг нэг зүйл ургамал, сөөхий гуталд дэвсэж өмсөнө.

ШОРОВГОР шорвигор.

ШОРОЙ (Н) шороо.

ШОРОН (Г) I олноос онцгой өндөр гарсан уул хад.

ШОРОН (Г) II гэмт хэрэгтэн **этгээдийг** хорих орон сав; гяндан ч гэнэ; **шорон гяндан** х о р ш.; *шоронд хорих; шоронгийн хуяг.*

ШОРОО (Н) 1. дэлхийн гадрагыг бий болгогч сэвсгэр бодис; **газар шороо** х о р ш.; *хар шороотой хөрс; тайлаг тайлаг тэмээнээс таван атга шорооноос* (оньсго худалдах үг); *төрсөн нутгийн шороо-алт* х у у ч; **шороо тавих** (шороо хийсгэж салхилах; *хавар болохоор шороо тавина даа);* **шороон хороо** (шороог овоолон барьсан хороо овоо); **шороон будаг** (чулуулгаас бий болсон будаг): 2. тоос; **шороо тоос** х о р ш.; *шороо тоосонд дарагдах; шороо тоос болох;* 3. **х у у ч и р с а н** дөрвөн махбодын дотоод нэг зүйл.

ШОРТОЙ 1 .хүний ам гашуун, үг аймшигтайгий нь; 2. аливаа юмны шор амттайгий нь.

ШОРХИРОХ унтсан хүний амьсгалах.

ШОРЧИГНОХ бяцхан усны урсах чимээ гарах.

ШОХОЙ шохойн чулууг шатааж гарган авдаг кальцийн исэл болох цагаан бодис; **шохойн чулуу** (шохой бүхий тундас чулуулаг).

ШОХОЙДОХ шохойгоор будах.

ШОХОЙДУУЛАХ шохойдохын үйлдүүлэх хэв.

ШОХООРОХ юманд дурлаж сонирхох байдал гаргах; *юманд шохоорхох.*

ШОХООРУУЛАХ шохоорохын үйлдүүлэх хэв.

ШОХООРХОХ маш их хүсч дурлах.

ШОХООРХУУЛАХ шохоорхохын үйлдүүлэх хэв.

ШОШ у р г а м а л тэжээлийн нэг наст буурцагт ургамал, буурцаг нь гонзгой бөөрөнтийвтөр хэлбэртэй, малд сайн тэжээлтэй, төрөл зүйл олон; **түрэг шош** у р г а м а л (нэг наст буурцагт ургамал, ур нь нарийн, гонзгой).

ШОШГО бичигтэй тэмдэг мод, бичиг тэмдэгтэй пайз.

ШӨВГӨР шөвх үзүүртэй юм; *шөвгөр хутга; шөвгөр гутал; шөвгөр үрүүл.*

ШӨВГӨРДҮҮЛЭХ шөвгөрдөхийн үйлдүүлэх хэв.

ШӨВГӨРДӨХ хэтэрхий шөвгөр болох.

ШӨВГӨРХӨН арай шөвгөр, нилээд шөвгөр.

ШӨВИЙЛГӨХ шөвийхөд хүргүүлэх, шөвгөр болгох.

ШӨВИЙХ шөвгөр болох.

ШӨВӨГ цоолох нүхлэх хэрэгсэл, гол төлөв төмөрлөгөөр хийнэ; **хутга шөвөг** х о р ш.; **шөвгийн бөх** (а. барилдаж түрүүлсэн бөх; б. таваас дээш давсан бөхчүүд); **шөвгийн даваа** (барилдах наадмын тавдугаар үе).

ШӨВӨГДӨХ 1. шөвгөөр хатгаж нүхлэх; 2. буудыг өдөөж хатгах.

ШӨВӨГДҮҮЛЭХ шөвөгдөхийн үйлдүүлэх хэв.

ШӨВӨГЛӨХ 1. шөвөгдөх; 2. шөвөгрөх.

ШӨВӨГЛҮҮЛЭХ шөвөглөхийн үйлдүүлэх хэв.

ШӨВӨГРӨХ 1. наадам тэмцээнд барилдах түрүүлэх; 2. мөн наадамд таваас дээш давах.

ШӨВХ шовх, хурц шөвгөр үзүүртэй юм.

ШӨВХГӨР шөвх, шовх.

ШӨВХГӨРДӨХ хэтэрхий шөвх болох.

ШӨВХГӨРДҮҮЛЭХ шөвхгөрдөхийн үйлдүүлэх хэв.

ШӨВХГӨРХӨН баахан шөвхгөр, арай шөвхгөр.

ШӨВХИЙХ шөвхгөр болох.

ШӨВХЛӨХ шөвх болгох.

ШӨВХРӨХ шөвх болох.

ШӨЛ тутрага, идэшний ногоо, загас мах тэргүүтэнг буцалгаж хандалсан шингэн идээ; **мах шөл** х о р ш.; *шөл уух; шөл хийх; ногооны шөл; ногоотой шөл; хоосон шөл; төлөөр баяжиж шөлөөр цаддаг* х у у ч; **шинэ шөл** (саявтар алсан малын махаар хийсэн шөл); **хар шөл** (дан махыг хэрчин буцалгаж гаргасан шөл); **шөл гаргах** (а. махыг *шөл бий болтол* буцалгах; б. мал алах; *танайх шөл гаргасан уу*).

ШӨЛГҮЙ шөл байхгүй; *шөлгүй хоол.*

ШӨЛГҮЙДҮҮЛЭХ шөлгүйдэхийн үйлдүүлэх хэв.

ШӨЛГҮЙДЭХ хэтэрхий шөлгүй болох.

ШӨМБИЙЛГӨХ шөмбийхийн үйлдүүлэх хэв.

ШӨМБИЙХ шөмбөгөр болох.

ШӨМБӨГӨР шомбогор, шөмбөн, цомбогор.

ШӨМБӨН шөмбөгөр, цомбогор.

ШӨНӨ нэгэн хоногийн үдшээс гэгээрэх хүртлэх цаг; *шөнийн цаг; шөнийн харанхуй; шөнийн манаа; өдөр гурвалжин, шөнө дөрвөлжин тэр юу вэ?* (оньсго); **шөнө дуусан** (шөнийн турш, шөнөжин); **шөнө дүл** (шөнө дунд); **шөнө шөнө** (шөнө бүр, шөнө болгон; *шөнө шөнө халуун нь буурсаар байв);* **шөнийн ээлж** (ээлжийн ажилчдын шөнө хийх ажил); **шөнө өдөргүй** (зай завгүй, зогсоо чөлөөгүй; *зудын үеэр малчид шөнө өдөргүй малын хойноос явсаар байв*).

ШӨНӨЖИН шөнийн туршид; *шөнөжингөө яваад өнөөдөр ирэв;* **өдөржин шөнөжин** (зай завгүй, зогсоо чөлөөгүй; *барилгын ажилчид өдөржин шөнөжин ажилласаар байв*).

ШӨНТГӨР зарим юмны хэвийн жишээнээс шонтгоры нь; *шөнтгөр хамар; шөнтгөр гутал.*

ШӨНТИЙЛГӨХ шөнтийхөд хүргүүлэх.

ШӨНТИЙХ шөнтгөр болох; *хамар нь шөнтийх.*

ШӨНХГӨР шөнтгөр, шонтгор.

ШӨНХИЙХ шөнхгөр болох.

ШӨР шөрөг.

ШӨРВИЙЛГӨХ шөрвийхөд хүргүүлэх.

ШӨРВИЙХ шөрөвгөр болох.

ШӨРВӨГНӨХ шөрөвгөр юмны шөрвөг шөрвөг хөдлөх.

ШӨРВӨЛЗӨХ шөрөвгөр юмны шөрвөс шөрвөс хөдлөх.

ШӨРВӨС (ӨН) шөрмөс.

ШӨРВӨСТЭЙ чадал тэнхээ ихтэй, чийрэг чадамгай, шөрмөстэй.

ШӨРГӨӨЛГӨХ шөргөөхөд хүргүүлэх.

ШӨРГӨӨХ амьтны юманд үтрэх; *морь мал гэр шөргөөх; хамуутай мал шөргөөх нь хэцүү.*

ШӨРМӨС (ӨН) амьтны биед байдаг булчингийн бүлх шандас; **шөрмөс шандас** х о р ш.; **шөрмөс татах** (шөрмөс агчин аягүй болох); **шөрмөсөн чулуу** (шөрмөс мэт ширхэг бүхий нэг зүйл чулуулаг, галд тэсвэртэй, юм хийхэд хэрэглэнэ).

ШӨРМӨСЛӨХ 1. шөрмөсий нь ялгаж авах; 2. ш и л ж с э н чийрэг чадалтай болох.

ШӨРМӨСРӨХ шөрмөс мэт байдалтай болох.

ШӨРМӨСТ шөрмөстэй.

ШӨРМӨСТӨХ шөрмөстэй болох.

ШӨРМӨСТЭЙ 1. шөрмөс бүхий; 2. ш и л ж с э н чийрэг, чадалтай.

ШӨРӨВГӨР шөрвийсөн байдалтай; *шөрөвгөр сахал; үс нь шөрөвгөр.*

ШӨРӨГ 1. гол төлөв дээд этгээдэд шовх үзүүр гарган хийсэн сараалж хашаа, хайс; 2. эхэд нь хөхүүлэхгүйн тулд төл малын хамарт **уяж торгох хэ**рэгсэл; *тугалд шөрөг хийх.*

ШӨРӨГДӨХ шөргөөр хатгах.

ШӨРӨГЛӨХ шөрөг хийх, шөрөгтэй болгох. • •

ШТАБ 1. цэргийн захирах командлалын байгууллага; *штабын дарга; хорооны штаб; корпусын штаб;* **жанжин штаб** (цэрэг дайны бүхий л арга ажиллагааг боловсруулах, бэлтгэх удирдах дээд байгууллага); 2. ш и л ж с э н аливаа удирдах байгууллага; *нам бол ажилчин ангийн дайчин штаб мөн.*

ШУАЙЗ юм цэвэрлэх арчих хэрэгсэл, тохируулсан мод зэргийн юманд хатуу үс, хялгасыг суулгаж үйлдэнэ; *шүдний шуайз; хувцасны шуайз; гутлын шуайз.*

ШУАЙЗДАХ шуайзаар зүлгэх, арчих цэвэрлэх; *шүдээ шуайздах; гутал шуайздах.*

ШУАЙЗДУУЛАХ шуайздахын үйлдүүлэх хэв.

ШУВТ 1. хүч нэмэгдүүлэх үг, нэвт; **нэвт шувт** х о р ш.: **шувт татах** (амьтны арьс зэргийн юмыг угзран татаж авах); **шувт харвах** нэвт харвах); **шувт хатгах** (нэвт хатгах); **шувт шаах** (мэс зэргээр юмыг нэвт дүрэх); 2. шууд, шулуун, тууш; *хоршоо дэлгүүрээр шувт хэсэв; шувт явсаар байгаад үүр цайлгав; шувт давхих;* 3. үргэлж, тувт, туж; *хурал дээр шувт суусан; шөнө шувт яваад ирэв.*

ШУВТАЙЛГАХ шувтайхад хүрүүлэх. • •

ШУВТАЙХ шувтгар, шувтан болох. • •

ШУВТАЛГАХ шувтлахад хүрүүлэх.

ШУВТАЛЗАХ шувтгар юмны шувтас шувтас хөдлөх.

ШУВТАН нэг этгээд нарийн шувтгар, нөгөө этгээд өргөн бүдүүн. • •

ШУВТАНДАХ хэтэрхий шувтан болох.

ШУВТАНДУУЛАХ шувтандахын үйлдүүлэх хэв.

ШУВТАРГАХ шувтрахад хүрүүлэх. • •

ШУВТГАНАХ шувтгар юмны шувтга шувтга хөдлөх. • •

ШУВТГАР юмны нэгэн этгээд нарийн цүүргэр байдалтайгий нь. • •

ШУВТГАРДАХ хэтэрхий шувтгар болох.

ШУВТГАРДУУЛАХ шувтгардахын үйлдүүлэх хэв.

ШУВТГАРХАН баахан шувтгар, нилээд шувтгар.

ШУВТЛАХ I 1. юмыг нэвтлэн туулах, цоолж нүх гаргах; **нэвтлэх шувтлах, шувтлах цоолох** х о р ш.; 2. дуусгах, шувтаргах; *би энэ ажлыг шувтлаад хөдөө явна.*

ШУВТЛАХ II хүний хувцас, өмд, малын арьс үс зэргийг тайлж хуучиж авах; ☆ **шар шувтлах** (ламын санваарыг эвдэж хар болгох); **ял шувтлах** (ялыг цагаатгах).

ШУВТЛУУЛАХ шувтлахын үйлдүүлэх хэв.

ШУВТРАГА үйл ажлын дуусгал төгсгөл; *ажлын шувтрага болов; наадам шувтрав; хэргийн шувтрагыг үзэх.*

ШУВТРАХ I 1. үйл ажил дуусах, барах, төгсгөл болох; *ажил шувтрах; өр төлбөр шувтрах; жил шувтрах; хооллож шувтрах;* 2. юмны гадуур өмсгөсөн зүйл сугарах тайлагдах; *өмд шувтрах; арьс нь шувтрах;* 3. юмыг урт тийш нь гараар хавчин шахаж татах; *сахал шувтрах; үс шувтрах; гэзгээ шувтрах;* 4. юм юмыг нэвт туулах, цоолж нэвтрэн гарах: **нэвтрэх шувтрах** х о р ш.; *харвасан сум нь гөрөвсийг шувтран гарсан байв.*

ШУВТРАХ II юмны дотоодод байгаа зүйлийг гараар хавчин шахаж гадагш гаргах; *гэдэс шувтрах; хөх шувтрах.*

ШУВТРУУЛАХ шувтрахын үйлдүүлэх хэв.

ШУВТЧИХ 1. байн байн шувтрах, шувтлах; 2. алиаа үйл явдал бүрмөсөн шувтрах, дуусах.

ШУВТЧУУЛАХ шувтчихын үйлдүүлэх хэв.

ШУВУУ (Н) бүлээн цуст, сээрт амьтан, биедээ өд өрөвлөг жигүүртэй, өндгөөр үржинэ, зүйл ялгал маш олон; *зэрлэг шувуу; махчин шувуу; гэрийн шувуу; усны шувуу; ангир шувууны дэгдээхий хөө, арван сардаа жиргэнэ дээ хөө, аль газрын дудрай вэ хөө, намайг юундаа шоолов доо хөө* (ардын дуу); **нүүдлийн шувуу** (дулаан оронд өвөлжөөд, төрсөн нутагтаа ирж өндөглөх шувуу); **шувуу тэжээх** (шувууг үржүүлэх); **шувууны аж ахуй** (гэрийн шувууг үржүүлэн өсгөх хөдөө аж ахуйн салбар); **шувууны судлал** (амьтны аймгийн судлалын дотроос тусгайлан шувууны аймгийг ялган судлах судлал); **шувууны судлалч** (шувууны судлалд мэрэгжил бүхий хүн); **шувуун нудрага у р г а м а л** (ууланд ургадаг, үндсээр

нь гурил хийж идэг нэгэн зүйл навчирхаг ногоо); **шувуун хөл** у р г а м а л (хэлбэр байдал шувууны хөлтэй адил нэгэн зүйл ногоо); **шувуун таваг** у р г а м а л (хуурай чулуурхаг хөрстэй газраар 2—5 см. өндөр ургадаг ургамал, навч цайвар ногоон, цэцэг нь жижиг, ногоон байхад нь бог мал сайн иднэ, заан таваг ч гэдэг ☆ **цаасан шувуу** (цаасаар шувуу эрвээхэй мэт дүрс хийж утсаар уяад салхинд дэрвүүлэн наадах тоглоом).

ШУВУУХАЙ а м ь т а н янз байдал хятруу бялзуухайн адил, эрэгчин нь хушууны угаас толгойдоо хүртэл таван зурвас хар чандартай, эмэгчин нь чандаргүй нэгэн зүйл шувуу.

ШУВУУЧ (ИН) шувуу хариулах хүн: **тахиачин шувуучин** х о р ш..

ШУГАМ 1. алив гадрага дээр татсан нарийн зураас; *шулуун шугам; тахир шугам; шугам татах;* **шугам зураг** (ерөнхий боловсролын сургуульд үздэг нэг зүйл хичээл, шугам зураг бол сурагчдад техникийн зургийн анхны мэдэгдэхүүнийг сургаж, техникийн зургийг ухаарах, хялбар зургаар тухайн юмыг хийх дадлага олгоно); 2. алив үзэл санаа явдлын чиг зорилт; *намын жанжин шугам.*

ШУГАМДАХ шугам татах, шугамын ором гаргах; *цаас шугамдах; мод шугамдах.*

ШУГАМДУУЛАХ шугамдахын үйлдүүлэх хэв.

ШУГАМЛАХ шугам ором гаргах, шугамдах.

ШУГАМЛУУЛАХ шугамлахын үйлдүүлэх хэв.

ШУГАМТАЙ шугам бүхий; *шугамтай дэвтэр.*

ШУГУЙ голын зах дагуу ургасан ой мод; **ой шугуй** х о р ш.; **шугуйч хэрээ** а м ь т а н (шугуйд орших хэрээ).

ШУДРАГА I 1. шулуун тэгш, эгц, цэгц; **шулуун шудрага** х о р ш.; 2. чигч үнэнч, төлөв түвшин; **шудрага үнэнч** х о р ш.; *Эх орон ард түмэндээ үнэнч шудрага байх хэрэгтэй;* **шудрага хүн** (а. үнэнч хүн; б. шулуун хүн; в. давшилт хүн; *шудрага хүн төрөлхтөн энх тайвны төлөө тэмцэж байна);* **шудрага хөдөлмөр** (үнэнч хөдөлмөр; *шудрага хөдөлмөрөөрөө олсон юм);* **«Шудрага журам» медаль** (гэнтийн осол аюулаас улс олон нийтийн эд хөрөнгө, хүний амь биеийг аврах хэрэгт онцгой гавьяа байгуулсан иргэдийг шагнах медаль).

ШУДРАГА II шанз II.

ШУДРАГА III х у у ч и р с а н гэмтэн хэрэгтнийг гэсгээн цээрлүүлэхэд хэрэглэх нэг зүйл агдалсан хүлэг.

ШУДРАГАДАХ I хэтэрхий шудрага болох.

ШУДРАГАДАХ II шудрага хөгжмөөр тоглох.

ШУДРАГАДАХ III шудрагалан агдлах.

ШУДРАГАЛАХ 1. үнэнч шудрагыг барьж явах; 2. зам муруйхгүй явах.

ШУДРАГАСАХ шудрага болох.

ШУДРАГАСГАХ шудрагасахад хүргүүлэх, шудрага болгох.

ШУДРАГАТАХ улам шудрага болох.

ШУДРАГАТГАХ улам шудрага болгох.

ШУДРАГАХАН баахан шудрага, арай шудрага.

ШУЛАГДАХ шулахын үйлдэгдэх хэв.

ШУЛАМ тотгор болох зүйл, шулмас, шумнас.

ШУЛАХ 1. махыг яснаас салгаж авах; *хонины мах шулах;* 2. модны дурсыг хуулах, модыг нимгэн нимгэнээр цавчин авах; *дүнз шулах;* 3. ш и л ж с э н дарлан мөлжих, наймаа худалдаа хийхдээ бусдын юмыг бага үнээр авч өөрсдийнхөө юмыг өндөр үнээр худалдах; *газрын эзэд, тариачдыг шулан мөлжиж байв; дамын худалдаачид бусдыг шулан мөлждөг.*

ШУЛБА хүч нэмэгдүүлэх үг; *шулба цохих; шулба татах; шулба чанах.*

ШУЛГА хүний хэл тультраа, чулчраа; *шулга хэлтэй хүүхэд.*

ШУЛГАЛАХ арьс зэргийг зулгалах, шалбалах.

ШУЛГАЛУУЛАХ шулгалахын үйлдүүлэх хэв.

ШУЛГАНАХ шулга байдлаар ярих; *юу хэлж байгаа нь мэдэгдэхгүй шулганаж байв.*

ШУЛГАНУУЛАХ шулганахын үйлдүүлэх хэв.

ШУЛГАРАХ арьс зэрэг юм зулгарах, шалбарах.

ШУЛГАРУУЛАХ шулгарахын үйлдүүлэх хэв.

ШУЛГАЧИХ байн байн шулгалах.

ШУЛГУЙ хаврын давтмал хагд.

ШУЛДАН шулсан юм; *шулдан хаа.*

ШУЛДАС (АН) шулж авсан юм; *махны шулдас; модны шулдас.*

ШУЛДАСЛАХ шулдас болгох, шулах.

ШУЛМАС ш а ш и н аливаа үйлсэд хөнөөл тоггор учруулагч хий юм, дүд ч гэдэг.

ШУЛУУДАХ 1. хэтэрхий шулуун болох; 2. шийдэх; *би хөдөө явахаар шулуудав.*

ШУЛУУДУУЛАХ шулуудахын үйлдүүлэх хэв.

ШУЛУУЛАХ 1. шулахын үйлдүүлэх хэв; 2. шулагдах.

ШУЛУУН 1. муруй хазгайгүй цэх; *шулуун зам; шулуун шугам;* 2. хүний үйл явдал төв шудрага, түвшин томоотой; **шулуун шудрага** х о р ш.; *шулуун хүн:* 3. эд юмны өнгө хээнцэргүй, аргүй төв байдалтай; *шулуун эд; шулуун хийцтэй.*

ШУЛУУРАХ 1. шулуун болох; 2. үйл явдалд саад тотгоргүй болох; *энэ ажил ч одоо шулуурав.*

ШУЛУУСАХ шулуурах, шулуутах.

ШУЛУУСГАХ шулуусахад хүргүүлэх.

ШУЛУУТАХ 1. улам тэгш шулуун болох; 2. үйл явдалд санаа шийдвэрлэх, саад бартаагүй болох.

ШУЛУУТГАХ шулуутахад хүргүүлэх.

ШУЛУУТГУУЛАХ шулуутгахын үйлдүүлэх хэв.

ШУЛУУХАН арай шулуун, нилээд шулуун, шуудхан.

ШУМАЙЛГАХ шумайхад хүргүүлэх.

ШУМАЙХ шумгар болох.

ШУМБАХ 1. шунгах, умбах; *усанд шумбах;* 2. ш и л ж с э н ихэд хүсч шунах; 3. ш и л ж с э н элбэг юман дотор умбах, туйлах; *хоолонд шумбах; торгонд шумбах.*

ШУМБУУЛАХ шумбахын үйлдүүлэх хэв.

ШУМГАЙ шуусан нь; *шуумгай үзүүртэй;* **шумгай цавчуур** (газар эрэх зэвсэг).

ШУМГАЙВТАР баахан шумгай, арай шумгай.

ШУМГАЙДАХ хэтэрхий шумгай болох.

ШУМГАЙХАН баахан шумгай, арай шумгай.

ШУМГАР хэвийн жишээнээс харчгар хорчгор, туранги байдалтай юм; *шумгар жимс; шумгар хурга.*

ШУМНАС шулмас.

ШУМУУЛ а м ь т а н нэг зүйл бяцхан ялаа, хүн малыг хатгах нь хэцүү; *шумуулд хатгуулах.*

ШУНААЧ хэтэрхий шунахай.

ШУНАГ шунамгай, шунахай; *шунаг зантай хүн.*

ШУНАЛ шунах үйлийн нэр; *шунал ихэдвэл шулам болно* х у у ч.

ШУНАЛТ шунал бий.

ШУНАЛТАЙ шунал бүхий; *шуналтай этгээд; эдийн шуналтай хүн.*

ШУНАМГАЙ шунахай, шунамхай.

ШУНАМГАЙВТАР баахан шунамгай, арай шунамгай, шунахайвтар.

ШУНАМГАЙДАХ хэтэрхий шунахай болох, шунахайдах.

ШУНАМГАЙХАН арай шунамгай, баахан шунамгай, шунахайхан.

ШУНАМХАЙ шунахай, хэт шуналтай.

ШУНАМХАЙДАХ шунахайдах.

ШУНАНГИ шунаг хэтэрсний нь.

ШУНАХ юмыг эзэмших, авахын тулд хэтэрхий дурших, хүсэх, санаа хэлбэрэх; *эдэд шунах; өнгө мөнгөнд шунах.*

ШУНАХАЙ эд юманд маш ховдог шуналтай; *шунахай худалдаачин.*

ШУНАХАЙДАХ шунахай нь нэндэх, хэтэрхий шунахай болох.

ШУНАХАЙВТАР баахан шунахай, арай шунахай.

ШУНАХАЙЛАХ үлэмж шунахай зан гаргах.

ШУНАХАЙРАЛ шунахайрах үйлийн нэр; *шунахайрал нь хэтрэх.*

ШУНАХАЙРАХ шунахай зан гаргах, ховдоглох.

ШУНАХАЙРУУЛАХ шунахайрахын үйлдүүлэх хэв.

ШУНАХАЙРХАХ хэтэрхий шунахай байдал гаргах.

ШУНАХАЙХАН баахан шунахай, нилээд шунахай.

ШУНГААЧ I шунгадаг, шунадаг зантай.

ШУНГААЧ II: **шунгаач алаг** а м ь т а н бие цэнхэр нугас мэт бөгөөд хар алаг, усанд шунгахдаа чадамгай нэг зүйл шувуу.

ШУНГАГЧ 1. усан дотор ажил хийх хүн, ус үл нэвтрэх тусгай хувцас өмсөж шунгална; 2. х у у ч и р с а н усны гүн гүйхэн газрыг зааж тэмдэг дохио өгөх хүн.

ШУНГАЛАХ байн байн шунгах.

ШУНГАХ 1. ус зэрэгт шумбах, шурган орох; *усанд шунгах;* **шунгадаг завь** (усан дээгүүр, мөн усан доогуур шунгаж явдаг завь); **шунгадаг онгоц** (усан дээгүүр, мөн усан доогуур шунгаж явдаг хөлөг онгоц); 2. ш и л ж с э н архи, ашиг, өнгөнд хэтэрхий шунах, дурлах; 3. шувуу, ямар нэгэн юмыг цохиж шаах, шүүрэхээр дээрээс доош хүчлэн нисэх; *элээ шунгах; бүргэд шунгах.*

ШУНГУУЛАХ шунгахын үйлдүүлэх хэв.

ШУНУУЛАХ шунахын үйлдүүлэх хэв.

ШУНХ (АН) чулуулгаас гарах улаан өнгөтэй нэгэн зүйл будаг; **будаг шунх** х о р ш..

ШУНХДАХ шунхаар будах.

ШУНХДУУЛАХ шунхдахын үйлдүүлэх хэв.

ШУНХЛАХ хүндэтгэвэл зохих хүний хамраас цус гарах.

ШУРАГ I байшин барилга, хөлөг онгоц мэтийн дэргэд буюу дээр нь тулгуур далбаа мэтийг өлгөхөд зориулж бэлтгэсэн өндөр мод; *шураг мод босгох; хөлөг онгоцны шураг.*

ШУРАГ II эрэгдэн оруулж тогтоох юмс, эр эрэг ч гэдэг; **эрэг шураг** х о р ш..)

ШУРАГ III ус уруу хушууран шаажорсон газар.

ШУРАГДАХ эрэгдэх, шураглах; **эрэгдэх шурагдах** х о р ш..

ШУРАГДУУЛАХ шурагдахын үйлдүүлэх хэв.

ШУРАГЛАХ шураг хийж эргүүлэх.

ШУРАГЛУУЛАХ шураглахын үйлдүүлэх хэв.

ШУРГАЛАХ 1. байн байн шургах; 2. орохын муушаал; *чухал байгууллагад шургалан орох.*

ШУРГАЛУУЛАХ шургалахын үйлдүүлэх хэв.

ШУРГАХ 1. хөндий юман доогуур орох гарах; *гүүрэн доогуур шургах;* 2. юман доогуур гулдрин орж далд болох; *ус, газар доогуур шургах;* 3. юмны дотор аргалан орж багтах, шургалах ч гэнэ; *намд шургах; ажилд шургах;* 4. үйл ажилд ядран туйлдаж унах шахамдах, шургачих ч гэнэ; *шургаж унах.*

ШУРГУУ нөр; *шургуу ажиллах; шургуу зүтгэл; шургуу тулалдаан.*

ШУРГУУЛ шүүгээ савны нүд татуур; *ширээний шургуул.*

ШУРГУУЛАХ шургахын үйлдүүлэх хэв, шургахад хүргүүлэх.

ШУРГУУЛГА юм агуулах нүд татуур бүхий сав; *аяганы шургуулга.*

ШУРХНАВЧ өмдний гадуур давхацлан өмсөх хувцас.

ШУРХНАГ өмдний хоёр гуяны доод үзүүр.

ШУУ I хүний гарын тохойноос сарвуу хүртлэх хэсэг; *шуунаас нь барих.*

ШУУ II: **шуу гүйх** битүү хөөж хавдах; *хөл нь шуу гүйж орхижээ.*

ШУУГДАХ 1. шуухын үйлдэгдэх хэв; 2. амьтны туранхилж мах нь хомстох; *мах нь шуугдах.*

ШУУГИАН аливаа хөдөлгөөн, яриа дуу зэргээс гарах зохистой бус чимээ; **үймээн шуугиан** х о р ш.; *шуугиан гаргах;* **шуугиан дэгдээх** (олонд дуулиантай яриа тараах).

ШУУГИЛДАХ шуугихын үйлдүүлэх хэв, үймэлдэх: **үймэлдэх шуугилдах;** х о р ш.; *та нар битгий шуугилдаад бай!*

ШУУГИЛДУУЛАХ шуугилдахын үйлдүүлэх хэв.

ШУУГИНАХ аливаа юмны хүчтэй шуугин чимээ гарах.

ШУУГИУЛАХ шуугихын үйлдүүлэх хэв; *нохой шуугиулах.*

ШУУГИХ 1. ихээхэн буюу олон юмны үймээн, нүргээнтэй чимээ гарах; *салхи шуугих; ой мод шуугих; хүүхэд багачууд шуугих; ус шуугиж урсах;* 2. аливаа сайн муу үйл явдлын тухай олноороо хэлэлцэх; *зарим аймагт зуд болсон гэж шуугиж байна.*

ШУУД 1. шулуун, цэх; *шууд замдаа нийлэв; шууд хайчлаарай;* 2. сааталгүй; *шууд харцуу-*

лах; шууд ажилдаа орох хэрэгтэй; 3. эрс шудрага; *шууд хориглох; шууд эсэргүүцэх; шууд хүн; шууд зан.*

ШУУДАГ бөгсөнд өмсөх хувцас; **зодог шуудаг** х о р ш.; *бөхийн шуудаг; шуудаг өмд.*

ШУУДАГДАХ шуудгаас барих.

ШУУДАГДУУЛАХ шуудагдахын үйлдүүлэх хэв.

ШУУДАГЛАХ шуудаг өмсөх.

ШУУДАГЛУУЛАХ шуудаглахын үйлдүүлэх хэв.

ШУУДАЙ юм хум агуулах бүдүүлэг нэхсэн сав, *таар шуудай; хялгасан шуудай;* 2. мөн шуудай хэмжээтэй юм; *нэгдүгээр гурилаас нэг шуудай авав.*

ШУУДАЙЛАХ шуудайд хийх; *будаа шуудайлах.*

ШУУДАЙЛУУЛАХ шуудайлахын үйлдүүлэх хэв.

ШУУДАН 1. захидал бичиг, хөнгөн ачаа зэрэг юмыг нэг газраас нөгөөд хүргэх үүрэг бүхий албан байгууллага; *шуудангийн хороо; шуудан дээр очих; шуудангаар явуулах;* **шуудангийн зарлага** (шуудан зөөгч); **шуудан зөөгч** (шуудангаар ирсэн зүйлсийг зохих эздэд нь хүргэх албаны хүн); **шуудангийн хайрцаг** (шуудангаар ирэх явах бичиг захидал зэргийг агуулахаар тусгай бэлтгэсэн хайрцаг); 2. мөн шуудан хүргэх уналга; *шуудангийн машина; шуудангийн онгоц; шуудангийн тэргээр ирэв.*

ШУУДАХ шууд болох, шуудрах.

ШУУДРАХ үйл ажил хийх ба аян явдалд явах зэрэгт бэлхэн болж цэгцрэх, шуудах.

ШУУДРУУЛАХ шуудрахын үйлдүүлэх хэв.

ШУУЛГАХ шуухын үйлдүүлэх хэв.

ШУУЛГУУЛАХ шуулгахын үйлдүүлэх хэв.

ШУУМАГ шурхнаг, өмдний гуяны нарийн үзүүр; *өмдний шуумаг.*

ШУУМГАЙ нарийн шувтан байдалтай юм; *шуумгай мод; нэгэн үзүүр нь шуумгай.*

ШУУРАХ хүчтэй ширүүн салхилах; *цас шуурах.*

ШУУРГА хүчтэй салхи; **салхи шуурга** х о р ш.; **шуурга тавих** (үргэлжлэн хүчтэй шуурах).

ШУУРГАДАХ шуурганд ядарч доройтох; *мал шуургадах.*

ШУУРГАЛАХ шуурга болох, шуурах.

ШУУХ 1. дээш сөхөх, тээш болгох; *хормой шуух; хаяа шуух; шууж овоолох; ус үзээгүй байж гутал тайлах, уул үзээгүй байж хормой шуух* з ү й р; 2. амьтны мах барагдан турах; *мах нь шуух; тарга нь шуух.*

ШУУХАД: **хүүхэд шуухад** хүүхэд багачууд.

ШУУХАЙЛГАХ шуухайхын үйлдүүлэх хэв.

ШУУХАЙХ шуухгар болох.

ШУУХГАР шоохгор.

ШУУХИНАХ хамраараа амьсгалах чимээ гарах, шуухирах, шуухитнах; *хүүхдийн хамар битүүрч шуухинах.*

ШУУХИНУУЛАХ шуухинахын үйлдүүлэх хэв.

ШУУХИРАХ шуухинах, шуухитнах.

ШУУХИРУУЛАХ шуухирахын үйлдүүлэх хэв.

ШУУХИТНАХ шуухинах.

ШУУХИТНУУЛАХ шуухитнахын үйлдүүлэх хэв.

ШУШИГ хорин найман оддын нэгний нэр.

ШҮВТЭР 1. шээс шинхгийн үнэр, амт; *шүвтэр үнэр; шүвтэр амт;* 2. азот устөрөгч хоёрын нэгдэл болох эхүүн үнэртэй өнгөгүй хий; 3. шивтэр.

ШҮГЭЛ үлээж дуугарган дохио өгөх хэрэгсэл; *цагдаагийн шүгэл хангинаж сонсдоно.*

ШҮГЭЛДҮҮЛЭХ шүгэлдэхийн үйлдүүлэх хэв.

ШҮГЭЛДЭХ шүгэл дуугаргах, шүгэл татах.

ШҮД (ЭН) 1. амьтны амны дотоод дахь, хазуур олон яс; *үүдэн шүд; араа шүд;* **шүдээ хавирах** (шүдээ харшуулан дуугаргах); **шүдээ ярзайлгах** (уруулаа сөхөж шүдээ ил гаргах); **шүд зуурах** (өвчний учир ам ангайхгүй болох): **шүд зуух** (а. зовлон бэрхшээлтэй цагт хатуужин тэсвэрлэх; б. бусдад өс хонзон санаж сэтгэлдээ хатангатган занах); **шүдний шуайз** (шүд зүлгэж цэвэрлэх хэрэглэл, хялгас татаж хийнэ); **шүдний оо** (шүд өнгөлөх ариутгах будаг мэт зүйл); **шүд ургах** (шүд

бий болох, шүдтэй болох); **шүд гарах** (а. шүд ургах; б. юманд шүд мэт зүйл бий болох); 2. зарим юмны шүд мэт ир; *хөрөөний шүд; саврын шүд; тармуурын шүд;* **шүд гаргах** (юманд шүд бий болгох).

ШҮДГҮЙ шүд унасан нь; шүд байхгүй; *шүдгүй өвгөн; шүдгүй үнээ; шүдгүй нохой булуу хураах* з ү й р.

ШҮДЛҮҮЛЭХ шүдлэхийн үйлдүүлэх хэв.

ШҮДЛЭН 1. адуу үхэр зэрэг гурван настай амьтан; *шүдлэн үрээ; даага шүдлэн;* 2. хонь ямаа зэргийн хоёр настайг нь.

ШҮДЛЭХ 1. амьтны шүд гарч ургах ба төрсний дараа гарсан шүд нь унаж дахин шүд гарах); *хүүхэд шүдлэх;* 2. малын шүдийг татан үзэж хөгшин залуугий нь ялгаж мэдэх; *мал шүдлэх; морь шүдлэх;* 3. зарим юманд шүд гаргах, шүдтэй болгох; *савар шүдлэх; тармуур шүдлэх.*

ШҮДЭНЗ чүдэнз, ноцоолго.

ШҮДЭТ шүд бүхий.

ШҮЙ гааль, түрээс; *шүй хураах.*

ШҮЙЛҮҮЛЭХ шүйлэхийн үйлдүүлэх хэв.

ШҮЙЛЭХ гааль хураах, түрээс хураах.

ШҮЛИЙТЭХ ямар нэгэн үйл явдалд санаа шулуудаж зүтгэн явах; *дуртай үйлдээ санаа шүлийтэх нь заавал илүү байдаг.*

ШҮЛМҮҮС шилмүүс.

ШҮЛМҮҮСТ шилмүүст.

ШҮЛМҮҮСТЭХ шилмүүстэх.

ШҮЛС (ЭН) I амьтны жавжны булчирхайгаас гарах шингэн зүйл, шүүс: *шүлс залгих;* **шүлс хазах** (юмыг санаанд тэсгэлгүй хүсч шунал төрөх); **шүлс асгарах** (юманд маш дурлаж хорхой хүрэх); **шүлс гоожих** (шүлсээ савируулах); **аалзны шүлс** (аалзны тусгай бучирхайгаас гарах нарийн утас, мөн утсан тор).

ШҮЛС II шүлхий II.

ШҮЛСДҮҮЛЭХ шүлсдэхийн үйлдүүлэх хэв.

ШҮЛСДЭХ юманд шүлс түрхэх ба юман дээр шүлс дусаах.

ШҮЛСТЭХ шүлс өвчин тусах, шүлхийтэх.

ШҮЛТ 1. шим, охь; 2. лакмус цаасыг дүрвэл хөх өнгөтэй болгодог химийн хахуун нэгдэл; *шүлтийн урвал.*

ШҮЛТҮҮЛЭХ шүлтэхийн үйлдүүлэх хэв, шүлтэхэд хүрүүлэх.

ШҮЛТЭГНЭХ тэсгэлгүй элэгсэг байдал гарган аашлах.

ШҮЛТЭХ I маш хүсч дурлах, шимтэх ч гэдэг; *ном шүлтэж унших; зураг харж шүлтэх; амттанд шүлтэх.*

ШҮЛТЭХ II шилтэх.

ШҮЛҮҮС шилүүс.

ШҮЛХИЙ I шүлс гоожин савирч явдаг; *шүлхий хүүхэд.*

ШҮЛХИЙ II үхэр гахайд тусах нэгэн зүйл халдварт өвчин, шүлс ч гэдэг.

ШҮЛХИЙ III у р г а м а л навч их болоод урт, иш ургаж түрүү гардаг нэгэн зүйл ургамал, борлуулж иднэ; **шүлхий шиш** у р г а м а л (өнгө цайвар нэг зүйл тариа, боорцог боов хийж идвэл болно); **шүлхийн тутрага** у р г а м а л (тутрагатай адил бөгөөд жижиг, чанах жигнэхэд түргэн болно, нялцайх нь хялбар нэгэн зүйл цагаан будаа); **шүлхий монгол амуу** у р г а м а л (тариа, боорцог амс хийж идэж болдог нэгэн зүйл амуу).

ШҮЛХИЙРЭХ 1. шүлхий болох; 2. шүлхийтэх.

ШҮЛХИЙТЭХ шүлхий өвчин тусах.

ШҮЛХТҮҮЛЭХ шүлхтэхийн үйлдүүлэх хэв.

ШҮЛХТЭХ 1. ямар нэгэн зүйлд хэт шунаж хүсэх дурлах; 2. шилтэх, шимтэх.

ШҮЛЭГ үгийг айзамд тохируулж. бадаглан бичсэн уран зохиолын нэг хэлбэр; *шүлэг бичих; шүлэг зохиох; шүлэг унших; шүлгийн төгсгөлт; толгой холболт.*

ШҮЛЭГЛҮҮЛЭХ шүлэглэхийн үйлдүүлэх хэв.

ШҮЛЭГЛЭЛ шүлэглэсэн зохиол; *шүлэглэл зохиол; шүлэглэл дуулал.*

ШҮЛЭГЛЭХ утга уянга нийлүүлэн шүлэг болгон зохиож бичих, хэлэх.

ШҮЛЭГЧ шүлэг зохиохдоо чадамгай; *зохиолч шүлэгч нар.*

ШҮЛЭР үнэ гэдэг бяцхан амьтны өөр нэр.

ШҮР (ЭН) а м ь т а н 1. далай доторхи хад асганд байдаг үл хөдлөх амьтан; 2. мөнхүү эдээр хийсэн чимэглэл; **шүр сувд** х о р ш.: *шүрэн чимэг;* **шүр бялзуухай** а м ь т а н (далан хэлт чогчигтой адил, толгойдоо цэцэгтэй, биеийн чандар хар, хэрэлдэх зантай нэгэн зүйл шувуу).

ШҮРГҮҮЛЭХ шүргэхийн үйлдүүлэх хэв.

ШҮРГЭХ юманд дөнгөж хүрэх, хавирах; *шүргэж өнгөрөх; гары нь шүргэн хөдөлгөх;* **шүргэх гийгүүлэгч** (өгүүлэхэд өгүүлэхийн эрх-

тэн хамжихгүй гийгүүлэгч.

ШҮРШИХ шингэн зүйлийг юманд үсэргэн сацах; *үнэртэй ус шүрших; цэцэг шүршиж услах.*

ШҮРШҮҮЛ шүршдэг хэрэгсэл, шүршүүр.

ШҮРШҮҮР шингэн зүйлийг шүршин гаргах хэрэгсэл; **шүршүүрт орох** (шүршин гарах усаар биеэ угаах).

ШҮТЛЭГ шүтэх үйлийн нэр; **шашин шүтлэг** х о р ш..

ШҮТҮҮЛЭХ 1. шүтэхийн үйлдүүлэх хэв; 2. шүтэгдэх.

ШҮТЭХ гүнээ итгэх, бишрэх; **шүтэх бишрэх, шүтэх итгэх** х о р ш.; **нэг хүнийг тахин шүтэх** (нийт олны амжилт бүтээлийг нэг хүнийх болгож магтан өргөмжлөх).

ШҮТЭЭН шүтэх юм; **бурхан шүтээн** х о р ш..

ШҮҮ азот хүчлийн давс, малд идүүлэх ба арьс элдэх мөн техникт ч хэрэглэнэ

ШҮҮГДЭХ шүүхийн үйлдэгдэх хэв.

ШҮҮГЧ 1. шүүхэд орсон хэргийг эрхлэн байцаах, хянаж шийтгэх хүн; *ардын шүүгч;* 2. биеийн тамирын наадмын дүрмийг баримтлан шүүх хүн; *шатрын шүүгч; тэмцээний ерөнхий шүүгч; олон улсын шүүгч цолтой хүн.*

ШҮҮГЭЭ (Н) аливаа юмыг хадгалахад зориулан үйлдсэн хаалга бүхий босоо, сав; *хувцасны шүүгээ; номын шүүгээ; ханын шүүгээ; тольтой шүүгээ;* **үл шатах шүүгээ** (галд тэсвэртэй төмрөөр үйлдсэн шүүгээ).

ШҮҮГЭЭЛЭХ юмыг шүүгээд агуулах.

ШҮҮДҮҮЛЭХ шүүдэхийн үйлдүүлэх хэв.

ШҮҮДЭР агаараас бууж ирдэг маш жижиг усан дуслууд; **шүүдэр буух** (өвс мод зэрэгт чийг шүүдэр тогтох); **шүүдэр тогтох** (өвс модны навчинд шүүдэр чийг бий болох).

ШҮҮДЭРТЭХ шүүдэр унаж тогтох.

ШҮҮДЭХ нэхий арьсыг шүүтэй шар сүү буюу усанд дүрж дарах; *арьс шүүдэх; шир шүүдэх.*

ШҮҮЛГЭХ 1. шүүхэд хүргүүлэх; 2. шүүгдэх.

ШҮҮЛҮҮЛЭХ шүүлэхийн үйлдүүлэх хэв.

ШҮҮЛЭХ арьс нэхийг шүүдэх.

ШҮҮМЖ аливаа ном зохиол, жүжиг, хөгжим зэргийг шүүмжлэн үзэж өгсөн үнэлэлт; *шүүмж бичих; бяцхан шүүмж; номын шүүмж гарах.*

ШҮҮМЖЛҮҮЛЭХ 1. шүүмжлэхийн үйлдүүлэх хэв; 2. шүүмжлэгдэх.

ШҮҮМЖЛЭГДЭХ шүүмжлэхийн үйлдэгдэх хэв.

ШҮҮМЖЛЭГЧ шүүмжлэх хүн; *утга зохиолын шүүмжлэгч.*

ШҮҮМЖЛЭЛ 1. аливаа зүйлд үнэлэлт өгөхийн тулд харилцан хэлэлцэх үйлийн нэр; **санал шүүмжлэл** х о р ш.; *шударга шүүмжлэл; ажил хэргийн чанартай шүүмжлэл; хурц шүүмжлэл; эрс шүүмжлэл; шүүмжлэл эсэргүүцэх; шүүмжлэлийн мөрөөр арга хэмжээ авах; зургийн цэцэг бороонд гутах шиг, зусрын сайчууд зөвлөлгөөнд урвалзах, уулын цэцэг бороонд сэргэх шиг, ухаантан сайчууд шүүмжлэлд баясах* з ү й р; **шүүмжлэл, өөрийн шүүмжлэл** (Марксист нам болон хөдөлмөрчдийн байгууллагын үйл ажиллагаанд бий дутагдал, алдааг илрүүлэх, засах үндсэн арга); 2. дутагдалтай, алдаатай газрыг заасан үг; *шүүмжлэлтэй хандах.*

ШҮҮМЖЛЭХ аливаа зүйлд үнэлэлт өгөх болон алдаа дутагдал, гажуу бурууг илрүүлэн засахаар хэлэлцэх; *шүүмжлэн хэлэлцэх; зөвлөлдөн шүүмжлэх; дутагдлыг хайр найргүй шүүмжлэх; шүүмжлэх хүмүүс нэрсээ бичээрэй.*

ШҮҮР I юмыг нарийлах, ялгах хэрэгсэл, *шанаган шүүр; шүүр хувин; тосны шүүр; шүүрээр шүүх.*

ШҮҮР II үс ноос зэргийг самнах сэмлэх шүд бүхий хэрэгсэл; **сам шүүр** х о р ш.; *гэзэгний шүүр; шүүрээр шүүрдэх.*

ШҮҮР III юмыг ариутгах цэвэрлэх хэрэгсэл; *тогооны шүүр; хогийн шүүр; өвсөн шүүр; хялгасан шүүр; бургасан шүүр.*

ШҮҮРГЭЛЭХ 1. малын явуут, өвсний толгой сэрмэн шүүрч идэшлэх; 2. яарч тэвдэх; 3. аливаа ажилд чармайх.

ШҮҮРДҮҮЛЭХ 1. шүүрдэхийн үйлдүүлэх хэв; 2. шүүрдэгдэх.

ШҮҮРДЭХ I 1. шүүрээр цэвэрлэх, ялгах; *гэзэг шүүрдэх; хог шүүрдэх;* 2. ш и л ж с э н аливаа байгууллага газрын бүрэлдэхүүнийг хянан үзэж зохисгүй муу этгээдүүдийг **хөөж** цэвэрлэх.

ШҮҮРДЭХ II юмны дотроос эрж сурвалжлах, олох; *хонь мал шүүрдэх; ном шүүрдэх; шүүрдэж эрэх; загас шүүрдэх.*

ШҮҮРМЭГ: шүүрмэг бин шингэн **зуурсан** гурилаар хайрч хийсэн нэг зүйл идээ.

ШҮҮРМЭГЛЭХ шүүрч гоожих, шүүрсхийх.

ШҮҮРҮҮЛЭХ шүүрэхийн үйлдүүлэх хэв, шүүрэхэд хүргүүлэх.

ШҮҮРХИЙ 1. мах зэрэг юмны баахан түүхийвтрий нь; *шүүрхий мах; шүүрхий хоол;* 2. ш и л ж с э н үйл ажлын дутуу дулим; *энэ бичсэн зүйл ч шүүрхий л байна даа.*

ШҮҮРХИЙДЭХ шүүрхий нь дэндэх, хэтдэх.

ШҮҮРХИЙЛЭХ шүүрхий болгох; *мах шүүрхийлж шарах.*

ШҮҮРЭХ I 1. юмыг бусдаас урьтаж сочмог булаан авах; *гараас нь шүүрэх;* 2. элээ бүргэд зэрэг амьтны жижиг амьтан ба юмыг базаж савардан аваачих; *элээ шүүрэх;* 3. юмыг гараар самардан авах; *шагаа шүүрэх; чулуу шүүрэх.*

ШҮҮРЭХ II 1. сав дахь юмны шингэн хувь нь гадагш нэвчиж гарах, гоожих; *аарц шүүрэх; ус нь шавхран шүүрэх;* 2. амьтны биенээс цус, шүүс, идээ бээр зэргийн нэвчиж гарах; *идээр шүүрэх; цус шүүрэх;* 3. газрын дороос ус зэрэг шингэн юмны дааварлан нэвчих; *ус шүүрэх.*

ШҮҮС (ЭН) 1. шим; **шим шүүс** х о р ш.; *шим шүүсийг сорч мөлжих;* 2. зочдод өгөх хоол зууш; **идээ шүүс, хоол шүүс** х о р ш.; *шүүс барих;* **хуурай шүүс** х у у ч и р с а н (албаны хүний хүнсийг мөнгөөр төлөх); **шүүс нийлүүлэх** х у у ч и р с а н (а. хамжлага ардаас феодалуудад малаар татвар өгөх: б. албан хэргээр өртөөгөөр явагсдад хоол зууш өгөх); 3. хоолонд шим шүлт оруулах зүйл.

ШҮҮС II 1. мод ургамал зэргээс гарах шингэн зүйл; *жимсний шүүс; чацарганын шүүс;* 2. яр шархны дотроос гарах шингэн ус, цус; 3. дарж даршуулсан зүйлийн шингэн хувь.

ШҮҮСЛҮҮЛЭХ шүүслэхийн үйлдүүлэх хэв.

ШҮҮСЛЭХ 1. юманд шүүс хийж найруулах; *мах шүүслэх;* 2. тоосго шаазан зэргийг түлж бэхжүүлэх; *тоосго шүүслэх;* 3. хүндэтгэвэл зохих хүний идээ хоол идэх; **шүүслэх уурхай** (шаазан ваар мэтийг түлэх зоорь).

ШҮҮХ I 1. үйл хэргийн учрыг байцаах, хянах, шийдвэрлэх; *хэрэг шүүх; байцаан шүүх;* 2. иргэний маргаан, эрүүгийн хэргийг хянан үзэж таслан шийдвэрлэдэг улсын байгууллага; **шүүх цааз** х о р ш.; *нүүдлийн шүүх; хэсгийн шүүх; хотын шүүх; аймгийн шүүх; Улсын дээд* ***шүүх; цэргийн шүүх; шүүхийн тогтоол;*** 3. х у у ч и р с а н эрүү тулгах; *жанчиж шүүх.*

ШҮҮХ II юмны буртаг холиогий нь шүүрдэн тунгаах, шингэн хувийг шүүрүүлж гаргах; *ус шүүх; аарц шүүх.*

ШҮҮХ III 1. ном бичгийг нийлүүлэн хянаж алдаа бурууг залруулах; *ном шүүх;* 2. юмны дотроос эрэх хайх; *айлын хотонд очиж мал шүүх.*

ШҮҮХ IV хожих, дийлэх; *шатар тоглож шүүв; хөзөрдөөд би шүүсэн.*

ШҮХЭР 1. нарны гэрлийг халхлан сүүдэрлэх хэрэгсэл, одоо нар борооны халх гэж нэрлэх болжээ; 2. х у у ч и р с а н ямбатан хүмүүсийн толгой дээр нь барьж явдаг дугараг чимэг.

ШҮХЭР II нисч яваа онгоцноос газар дээр юм буулгахад хэрэглэх нарны халх мэт тусгай хэрэгсэл; *шүхрээр буух; шүхрийн спорт.*

ШҮХЭР III у р г а м а л модлог иштэй, өдлөг дэрэвгэр навчтай нэг зүйл олон наст ургамал, малын тэжээлд төдий л сайн биш; **шүхэр цэцгийн язгуур** (шүхэр хэлбэртэй баг цэцэгтэй ургамлуудын язгуур).

ШҮХЭРЛЭХ тогос шувууны өд сөдөө дэлгэх; *тогос шүхэрлэж байна.*

ШЭЭ хүндийн хэмжээ, арван цэн буюу 36 граммтай тэнцэнэ.

ШЭЭЗГИЙ жижиг араг; **араг шээзгий** х о р ш.; **шээзгий сэвэг** (хулс зэгс, дэрс мэтээр сүлжиж хийсэн томоохон сэвэг сав).

ШЭЭЛГЭХ шээхэд хүргүүлэх; *хүүхэд шээлгэх.*

ШЭЭР у р г а м а л шидээс өндөрхөн нэгэн зүйл мод, үүнд ургасан боргоцой гурван хушуутай, шуумгай, хальс нимгэн.

ШЭЭРЭН байн байн шээх хүн; **шээрэн хорхой** а м ь т а н (өнгө хар, хатуу хальстай, жигүүртэй, хүний бие дээр шээвэл цөврүүтүүлэх хортой гэнэ).

ШЭЭС (ЭН) 1. бөөрөөр дамжин боловсорч гаргах, бие махбодод хортой шингэн зүйл, ялгадас; 2. бэлгийн сүвээр гарах мөнхүү шингэн; **шээс чавдаграх** (шээс ав авсаар гарахгүй болох); **шээс чавдагших** (шээс чавдаграх); **шээс хаагдах** (шээс гарахгүй болох).

ШЭЭХ шээс огоорч шингэн мөр үзэх.

ШЯН хэмжүүр, вийгийн аравны нэг хувь.

ШЯНЧУУ нянчуугийн адил бөгөөд баахан чангалаг нэгэн зүйл торгомсог бараа.

Э

Э Э үсэг, Э авиа.

ЭВ I 1. хүн амьтны хоорондын найр нийлэмж: **эв найрамдал, эв эе, эв зүй** х о р ш.: *эвийн эхэнд тос, эвдрэлийн эхэнд цус* х у у ч; *эрдмийг эхнээс нь, эвийг эртнээс нь* х у у ч; **эв хамт ёс** (коммунизм, пролетарийн хувьсгал, пролетарийн дарангуйлан захирах засгийн ялалтын үрээр капитализмын оронд бий болох нийгэмлэгийн байгуулал бөгөөд түүний үйлдвэрлэлийн харьцааны үндэс нь анги гэж ялгаварлах явдал байхгүйгээс гадна, хот тосгон хоёр хийгээд оюуны ба биеийн хөдөлмөр хоёрын хоорондын ялгаа арилсан, хуваарилалыг хэрэгцээний хирээр гүйцэтгэх зарчим болно); **эв нэгдэх** (санаа явдал зохицон нийлэлцэх, хавсралцах); **эв эвдрэх** (найрамдал эвдрэх); **эв нь эвдрэх** (а. найрамдал эвдрэх; б. хагарсан бутарсан юмны нийлбэл зохих газар нь нийлүүлж эвлүүлж боломгүй болох); **эв нийлэх** (а. санал сэтгэл, найр найрамдал зохицон нэгдэх: б. наах зүйх зэргийн юмны хоорондоо яв цав тохирох, таарах); **эв муудах** (а. найртай харилцаа эвдрэх; б. наах зүйх юмны нийлэмж муудах); 2. эд юмны хоорондоо явхийтэл нилэлцэх тохирлого; *эв нийлэх; эв нь салах; эвээр нь нийлүүлэх; эвт нь оруулах;* ☆ **эв мод** (хил хязгаарын харуул цэргийн хоёр этгээд, хайч солилцохдоо нийлүүлэн үзэх цуудас мод); 3. юмны тааламжлагдах ая зүй; *унахад эв сайтай морь; ачааг эв дүйтэй ачих;* **эв дүйгүй** (юмны эе зүйг олж чадахгүй, дүй муутай); **эв хавгүй** (юмны үзэмж тохиромжгүй, хэтэрхий болхи бүдүүлэг, дүй муутай зэргийг шоодож өгүүлэхэд хэрэглэнэ; *эв хавгүй биетэй амьтан; эв хавгүй яриатай хүн);* **эв зэвгүй** (дүйгүй, эв хавгүй, эв нь нийлэхгүй болсон).

ЭВ II эм халиу, эвий ч гэдэг.

ЭВГҮЙ 1. харилцан найр нийлэмжгүй, эв зэвгүй; *эвгүй барсаас эвтэй шаазгай дээр* х у у ч; 2. эдлэх хэрэглэхэд зохимжгүй; 3. тохиромжгүй; *олны дунд эвгүй байдал гаргах.*

ЭВГҮЙДҮҮЛЭХ эвгүйдэхийн үйлдүүлэх хэв.

ЭВГҮЙДЭХ хэтэрхий эвгүй болох.

ЭВГҮЙРХЭХ ээ эвгүй зан байдал гаргах.

ЭВГҮЙТЭХ улмаар эв нийлэмжгүй болох, тохиромж зохимжгүй болох; *бие эвгүйтэх.*

ЭВДЛҮҮЛЭХ 1. эвдлэхийн үйлдүүлэх хэв; 2. эвдлэгдэх.

ЭВДЛЭХ эвдрэхэд хүргүүлэх, эвдрүүлэх, байн байн эвдэх.

ЭВДРҮҮЛЭХ эвдрэхийн үйлдүүлэх хэв, эвдрэхэд хүргүүлэх.

ЭВДРЭЛ эвдрэх үйлийн нэр; **эвдрэл гэмтэл, эвдрэл сүйдэл, эвдрэл хямрал** х о р ш..

ЭВДРЭЛДҮҮЛЭХ эвдрэлдэхийн үйлдүүлэх хэв.

ЭВДРЭЛДЭХ эвдрэхийн үйлдэлдэх хэв.

ЭВДРЭЛЦҮҮЛЭХ эвдрэлцэхийн үйлдэлцэх хэв.

ЭВДРЭЛЦЭХ муудалцах, эвдрэлдэх.

ЭВДРЭХ 1. юмны бүрэн бүтэн байдал алдагдах; **эвдрэх хэмхрэх** х о р ш.; *эд юм элэгдэж эвдрэх; дүр байдал өөрчлөгдөж эвдрэх;* 2. найртай эетэй байдал алдагдах; *гэр бүлийн хүмүүс хэрэлдэж эвдрэх муухай байдаг; эв эвдэрснээс, эд эвдэрсэн нь дээр* х у у ч.

ЭВДРЭШГҮЙ юмны хялбар эвдрэмгүй, маш бат бэх чанартайгий нь; *эвдрэшгүй мөнх; эвдрэшгүй бат; Монгол-Зөвлөлтийн ард түмний эвдрэшгүй бат найрамдал.*

ЭВДҮҮЛЭХ 1. эвдэхийн үйлдүүлэх хэв; 2. эвдэгдэх.

ЭВДЧИХ байн байн эвдэх, олныг эвдэх, олон хэсэг болгож эвдэх, эвдлэх.

ЭВДЧҮҮЛЭХ эвдчихийн үйлдүүлэх хэв, эвдчихэд хүргүүлэх.

ЭВДЭГДЭХ эвдэхийн үйлдэгдэх хэв.

ЭВДЭГЧ эвдэх үйл гүйцэтгэгч этгээд; *хэв журам эвдэгч.*

ЭВДЭРХИЙ эвдэрч бүрэн бүтэнгүй болсон юм; **эвдэрхий хэмхэрхий** х о р ш.; *эвдэрхий авдар; эвдэрхий араг; эвдэрхий хот; эвдэрхий балгас.*

ЭВДЭХ 1. юмыг бүтэнгүй болгох, хэмхлэх; **эвдэх хэмхлэх** х о р ш.; *байшин савыг эвдэх;*

гэр оронг эвдэх; **мах эвдэх** (махыг хэсэглэн салгах); 2. найртай, эетэй, сайн санаа бодлыг буснуулах; *эв эвдэх; ааль авирыг эвдэх; найртай харилцааг эвдэх;* 3. х у у ч и р с а н албан үүргээс бүрмөсөн халах өөрчлөх; *түшмэл эвдэх; баатар цолыг эвдэх.*

ЭВИЙ энхрийлэн тансаглах буюу хайрлан өрөвдөхөд хэлэх аялга; *эвий зайлуул! эвий хөөрхий!* **эвий халхай** (хүүхдийг тэсгэлгүй хайрлахад гаргах аялга).

ЭВИЙЛҮҮЛЭХ эвийлэхийн үйлдүүлэх хэв.

ЭВИЙЛЭХ 1. өршөөн тансаглаж, эвий эвий гэж өгүүлэх; *хүүхдээ эвийлэх;* 2. хөөрхийлөх, өрөвдөх.

ЭВИХ эвүүр ааль заан гаргах.

ЭВЛҮҮЛЭГ эвлүүлсэн юм; *радио эвлүүлэг.*

ЭВЛҮҮЛЭГЧ эвлүүлэх үйл гүйцэтгэгч этгээд.

ЭВЛҮҮЛЭХ эвлэхийн үйлдүүлэх хэв, эвлэхэд хүргүүлэх, эвт нь оруулах.

ЭВЛҮҮР I эд барааг нэхэхэд утсан ширхгийг сууриин толгойд бооход ташаалж тавьсан иш; *эвлүүр мод.*

ЭВЛҮҮР II бусадтай зохицож найрамдахдаа хялбархан, эвлэг, эвцхэн ч гэдэг; *эвлүүр хүн; эвлүүр зантай хүүхэд.*

ЭВЛЭГ 1. зан ааш эелдэг нийлэмжтэй; *эвлэг зантай хүүхэд;* 2. эелдэг зөөлөн ялгум аятай юм; 3. элбэг.

ЭВЛЭЛ суртал зорилго нийлж нэгдсэн холбоо, байгууллага; **эвлэл холбоо, эвлэл эвсэл** х о р ш.; *залуучуудын эвлэл; үйлдвэрчний эвлэл; анчны эвлэл.*

ЭВЛЭЛДҮҮЛЭХ эвлэлдэхийн үйлдүүлэх хэв, эвлэлдэхэд хүргүүлэх.

ЭВЛЭЛДЭХ 1. санаа зорилго нийлэлцэн зохицож нэгдэх; 2. уулаасаа найрамдалгүй байсан буюу найр эвдэрсэн амьтны харилцан эвлэрэх, найралдах.

ЭВЛЭН: эвлэн ховлон уйлах нус нулимс зэрэгцэн, маш энэлэн уйлах.

ЭВЛЭРҮҮЛЭХ эвлэрэхийн үйлдүүлэх хэв, эвлэрэхэд хүргүүлэх.

ЭВЛЭРШГҮЙ эвлэрэх нөхцөл боломжгүй; *эвлэршгүй тэмцэл; эвлэршгүй дайсан.*

ЭВЛЭРЭГЧ эвлэрэх үйл гүйцэтгэгч этгээд; *манайд дутагдалтай эвлэрэгч тийм хүн байж бөлохгүй.*

ЭВЛЭРЭХ 1. зохицон найралдаж нэгдэх; **эелэх эвлэрэх** х о р ш.; *хэрэлдэж хэрэлдэж дараа эвлэрч гэнэ;* 2. аливаа буруу гажуу зүйлтэй найралдан зохицож явах; *ийм зохисгүй явдалтай эвлэрэн явж яаж болох билээ.*

ЭВЛЭХ 1. хүн амьтны зохирон найралдах, эвлэрэх,. нэгдэх; **эвлэх нэгдэх** х о р ш.; *эвлэвэл бүтнэ, ховловол гутна* х у у ч; 2. эд юмсын хоорондоо яв цав тохирох нийлэх, эвтээ орох нийцэх; 3. элбэх; **эвлэх элбэх** х о р ш..

ЭВРҮҮЛЭХ эврэхийн үйлдүүлэх хэв, эврэхэд хүргүүлэх.

ЭВРЭЛХЭГ эвэр мэт байдалтай.

ЭВРЭХ нойтон юмны бяцхан хуурай болж эгших; **эврэх эгших** х о р ш.; *угаасан хувцас эврэх.*

ЭВРЭЭЛГЭХ эврээхийн үйлдүүлэх хэв, эврээхэд хүргүүлэх.

ЭВРЭЭХ эврэхэд хүргүүлэх, эгшээх, эвргүүлэх.

ЭВСҮҮЛЭХ эвсэхийн үйлдүүлэх хэв, эвсэхэд хүргүүлэх.

ЭВСЭЛ 1. эвсэх үйлийн нэр; **эвлэл эвсэл** х о р ш.; 2. аливаа үйл ажлыг хамтран хийхийн тулд нам улс, олон нийтийн байгууллагын зүгээс түр байгуулах холбоо; *нам ба нам бусчуудын эвсэл; эвсэл холбоонд оролцох.*

ЭВСЭЛДҮҮЛЭХ эвсэлдэхийн үйлдүүлэх хэв.

ЭВСЭЛДЭХ эвсэхийн үйлдэлдэх хэв.

ЭВСЭХ 1. харилцан найралдах, эвлэн нэгдэх; 2. үйл ажилд хавсах, хамсах; **эвсэх хамсах** х о р ш.; *хоёулаа үүнийг эвсээд хийчихэе.*

ЭВТ эв сайтай; *эвт шаазгай буга барина* х у у ч; **эвт ах** (эх биш бөгөөглөө хөхнийхөө сүүгээр тэжээсэн хүн).

ЭВТЭЙ 1. эв бүхий юм; *хоёр хүн эвтэй бол төмөр хүрээ мэт бат, хорин хүн эвгүй бол эвдэрхий хүрээ мэт хэврэг* х у у ч; 2. юмны эе зүй тохиромж нийлэмж сайны нь; *та эвтэй ярих хэрэгтэй; эвтэй гэр бүл; эвтэй ширээ.*

ЭВТЭЙХЭН нилээд эвтэй, аятайхан; *эвтэйхэн хэлэх; их эвтэйхэн болов.*

ЭВҮҮ айх гаслахад гаргах аялга; *эвүү халаг! эвүү яадаг билээ!*

ЭВҮҮЛЭХ эвэхийн үйлдүүлэх хэв, эвэхэд хүрүүлэх.

ЭВҮҮР өөрийн чадварыг хэтэрхий дор болгон өгүүлэх буюу байгаа юмаа байхгүй гэх зэргээр өгүүлэх ярих заншилтай хүн; *эвүүр хүн; эвүүр зан; эвүүр амтай.*

ЭВХАМТ эв хамт ёс, коммунизм; *эв хамтын нийгэмлэг; эв хамтын үе.*

ЭВХАМТАЧ эв хамтын ёсыг баримтлагч.

ЭВХМЭЛ 1. эвхсэн юм, эвхдэг юм; *эвхмэл цаас; эвхмэл тонгорог; эвхмэл ширээ; эвхмэл сандал; эвхмэл ор;* 2. үсэг бичгийн янзлан эвхэж зурсны нь; *эвхмэл үсэг; эвхмэл бичиг; эвхмэл зураг.*

ЭВХРҮҮЛЭХ эвхрэхийн үйлдүүлэх хэв, эвхрэхэд хүрүүлэх.

ЭВХРЭЛДЭХ эвхрэхийн үйлдэлдэх хэв.

ЭВХРЭХ 1. хүн амьтны бие агдайх хорвойх; *эвхрэн хэвтэх; дотор эвхрээд байна;* 2. эд юмны эвхэгдэн атирах.

ЭВХҮҮЛЭХ 1. эвхэхийн үйлдүүлэх хэв, эвхэхэд хүрүүлэх; 2. эвхэгдэх.

ЭВХҮҮРЭГ эвхдэг юм; *эвхүүрэг хутга; эвхүүрэг ширээ.*

ЭВХЭС 1. нэг сөөм хир ишинд хэрээдэслэн авсан утас; 2. нэхмэлийн зүйлд орхицонд торгож эвлэх ширхэг.

ЭВХЭХ юмыг цом авсаар болгож хумхих хуйлах ба нугалах матруулах; *дээл хувцас эвхэх; сур дээс эвхэх; цаас эвхэх; наад даавуугаа эвхээд ав!*

ЭВХЭЭ эвхсэн юм; *эвхээ зах.*

ЭВХЭЭС эд бараа зэргийн эвхсэний нь; *эвхээс сайтай; эвхээс муутай; эвхээс нь задарчихсан байв.*

ЭВХЭЭСТЭЙ эвхээс бүхий юм.

ЭВХЭЭТЭЙ эвхээ бүхий юм, эвхээстэй юм.

ЭВЦҮҮЛЭХ эвцэхийн үйлдүүлэх хэв, эвцэхэд хүрүүлэх.

ЭВЦХЭН эвлэмтгий зантай хүн, эвчхэн ч гэдэг.

ЭВЦЭЛ 1. эвцэх үйлийн нэр; 2. мал адгуус, ургамлын хос нийлэхий нь.

ЭВЦЭЛДҮҮЛЭХ эвцэлдэхийн үйлдүүлэх хэв, эвцэлдэхэд хүрүүлэх.

ЭВЦЭЛДЭХ эвцэхийн үйлдүүлэх хэв.

ЭВЦЭХ 1. эвлэх, эвлэлдэх, эвсэх; 2. ургамал амьтны хос нийлэх, эр эм харилцан нийлэлдэх; 3. хоёр өэр зүйл хоорондоо нийлэн зохицож өөр төрөл бий болох; *мал адгуус эвцэх; ургамал эвцэх.*

ЭВЦЭЭХ 1. эвцүүлэх; 2. олноор эвлэлдэх.

ЭВЧ эв сайтай; *эвч зантай хүүхэд; эвч хүнд ижил хань олон.*

ЭВЧХЭН нилээд эвч.

ЭВШ маахай II-ын эм; **эвш адаг** (эм нохой өтөг).

ЭВШГЭС эм булга.

ЭВШЭЭЛГЭХ эвшээхийн үйлдүүлэх хэв, эвшээхэд хүрүүлэх; **нум эвшээлгэх** (нумыг барьж хөвчнөөс үгтээх).

ЭВШЭЭХ хүн амьтны нойр ойртох ба бие зүдэсхийсэн буюу чилсхийсний улмаас амаа ихээр ангайлган амьсгалыг дотогш татаж даруй гадагш нь гаргах; *хичээл хийж байхад эвшээх муухай.*

ЭВЭР I 1. амьтны толгойн яснаас ургаж гарсан дотроо тугалмай ястай зүйл, хуучин нь унаж шинээр солигдох солигдохгүй хоёр зүйл бий; *ишиг эврээ ургахаар эхийгээ мөргөх* х у у ч; **шуудайд хийсэн үхрийн эвэр шиг** (санаа бодол их л зөрөөтэй, эвгүй); 2. эврээр хийсэн юм; *эвэр сам; эвэр товч; эвэр иштэй тонгорог;* 3. хүн амьтны үс хумс; 4. хорхой шавьжийн толгойд ургасан туршуул; 5. хүүхдийн хөхөл, шувууны өвөг.

ЭВЭР II хүний гар хөлд хүчилсэн шахагдсан зэргээс үүсэн гарах үү мэт саарь; *хөлийн эвэр, хуруунд эвэр ургасан нь хөндүүрлээд байна.*

ЭВЭРДИЙ үхрийг эврээр оосорлоход хэрэглэх оосор.

ЭВЭРДЭХ эврээс нь барих.

ЭВЭРЖ а м ь т а н янз байдал шар нохойтой адилхан, нэг тогтсон газар баах заншилтай нэгэн зүйл гөрөөс.

ЭВЭРЖИХ эвэр мэт болох.

ЭВЭРЖҮҮ эвэр мэт байдалтай.

ЭВЭРЛЭГ I амьтны эвэр туурай, үс хумс зэргийн эврээр бүтсэн бодис; *эвэрлэг эд.*

ЭВЭРЛЭГ II а м ь т а н янз байдал морьтой адил, бие цагаан, сүүл хар, нэг эвэртэй, соёотой нэг зүйл араатан.

ЭВЭРЛЭГ III: **эвэрлэг мод** у р г а м а л эврийн адил дурстай нэг зүйл хатуу том мод.

ЭВЭРЛЭХ 1. эвэр бий болох; 2. зовох эвэршээх.

ЭВЭРТ эвэр бий; **эвэрт цох** а м ь т а н (дээд эрүүндээ эвэр мэт туршуултай нэгэн зүйл цох).

ЭВЭРТЭЙ эвэр бүхий юм; *эрээн л юм байна бар л юм байлгүй, эвэртэй л юм байна бух л байлгүй* (оньсго).

ЭВЭРХИЙ а м ь т а н янз байдал гахайтай адил, эвэртэй, бархиран дуугардаг нэгэн зүйл араатан.

ЭВЭРШИХ эвэр шинжтэй болох.

ЭВЭРШЭЭЛ тэсч ядам өвдөх зовлон; **зовлон эвэршээл** х о р ш..

ЭВЭРШЭЭХ тэсч ядам зовуурьтай өвдөх.

ЭГДҮҮ I. дур таалалд үл нийцэх зүйлийг жигших голох, сочиж зэвүүрхэх сэтгэгдэл төрөхий нь; *эгдүү хүрэх; эгдүү хөдлөх;* 2. хүүхэд зулзага зэргийг сонирхон хайрлах өхөөрдөл; *эгдүүтэй хүүхэд; эгдүү хүрмээр хөөрхөн амьтан;* 3. доог, тохуу.

ЭГДҮҮТЭЙ эгдүү бүхий юм; *эгдүүтэй хун; эгдүүтэй үг.*

ЭГДҮҮЦҮҮЛЭХ эгдүүцэхийн үйлдүүлэх хэв.

ЭГДҮҮЦЭЛ эгдүүцэх үйлийн нэр; *эгдүүцэл төрөх; эгдүүцэлтэй үйл явдал.*

ЭГДҮҮЦЭХ эгдүү хүрэх, эгдүү хөдлөх, эгдүүцэл төрөх; *могой хараад их л эгдүүцэв.*

ЭГДҮҮРХЭХ эгдүү хүрэх, сэтгэлд зэвүү төрөх, зэвүүрхэх.

ЭГЗЭГ юмны өө сэвтэй буюу сэжиглэлтэй хардалтай газры нь; *энэ хэргийн чухам эгзэг нь юундаа байна?; үйлийн өө мэдэхгүй мөртлөө, үгний эгзэг андахгүй* х у у ч; **эгзэг заам** (хувцасны зах ханцуй туурайн тойрон хөвөөлсөн хөвөө).

ЭГЗЭГЛЭХ өө сэв санах, хардах, сэжиглэх, болгоомжлох.

ЭГЗЭГТЭЙ эгзэг бүхий; *эгзэгтэй үг; эгзэгтэй хэрэг; үг нь эгзэгтэй байна, үнэнгүй биз ээ.*

ЭГНҮҮЛЭХ эгнэхийн үйлдүүлэх хэв, эгнэхэд хүргүүлэх.

ЭГНЭГТ хэзээд, хэрхэвч, лав, магад, ямар нэг юмыг үүнээс зайлах газаргүй гэсэн санаа; *эгнэгт үнэн; эгнэгт батална.*

ЭГНЭХ юмыг эн, энгээр нь жигдлэн үргэлж болгох; *даавуу эгнэх; дээлийн дотор эгнэх.*

ЭГНЭХ II олноор зэрэгцэн явах, зэрэгцэн жагсах; *эгнэж жагсах; эгнэж суух.*

ЭГНЭХ III хэмжээ хүч чинээгээр сацуу тэнцүү болох, эн зэрэгцэх, мөр зэрэгцэх; *түүнтэй эгнэх чадалтай хүн манай энд байхгүй; сурлагаар эгнэх.*

ЭГНЭХ IV даавуу зэргийг энгээр нь зэрэгцүүлэн хэмжих.

ЭГНЭХГҮЙ эн зэрэгцэхгүй, тэнцэхгүй, эгнүүлэн зэрэгцүүлж болохгүй.

ЭГНЭЭ (Н) 1. эгнэсэн нь; *гурван эгнээ; эгнээгээр жагсах; эгнээ байшин;* 2. бүрэлдэхүүн; *намын эгнээг бэхжүүлэх; ажилчин ангийн эгнээнд орох.*

ЭГҮҮЛЭХ эгэхийн үйлдүүлэх хэв, буцаах; *эгүүлэн өгөх; эгүүлэн авчрах; эгүүлэн олгох; хойш нь эгүүлэх.*

ЭГЦ 1. эрс, шулуун, цэх; *эгц уурга; эгц босоо; эгц гудамж; эгц харалдаа;* **эгц харах** (урдаас нь эрсэлж харах): **эгц хугарах** (хөндлөн эрс хугарах); **эгц шугам** (нэг шугам дээр тэгш өнөөг үүсгэх нөгөө шулуун шугам); 2. я р и а зориггой, шудрага, шийдэмгий; **эгц шудрага, эгц шийдэмгий** х о р ш.; *эгц хүн; эгц зориготой.*

ЭГЦДҮҮЛЭХ эгцдэхийн үйлдүүлэх хэв.

ЭГЦДЭХ хэтэрхий эгц болох.

ЭГЦЛҮҮЛЭХ эгцлэхийн үйлдүүлэх хэв.

ЭГЦЛҮҮР эгц шугам.

ЭГЦЛЭХ эгцрэхэд хүргүүлэх, эгц болгох.

ЭГЦРҮҮЛЭХ эгцрэхийн үйлдүүлэх хэв, эгцрэхэд хүргүүлэх.

ЭГЦРЭХ эгц болох, шулуусах, эрсрэх.

ЭГЦХЭН арай эгц, нилээд эгц.

ЭГЦЭВТЭР баахан эгц, нилээд эгц.

ЭГЧ 1. төрөл ургийн доторхи нас илүү буюу үе салаа зэргээр ахлах эмэгтэйчүүд; *төрсөн эгч; авга эгч; хадам эгч; нагац эгч;* 2. ердөө эмэгтэй хүний нас ахы нь; *тэр гуай надаас эгч; эгч дүү хоёр эн чацуу* (оньсго).

ЭГЧИС түргэн явцуу зантай; *эгчис хүн; эгчис зан; эгчис морь.*

ЭГЧМЭД нэг хүнээс төрсөн олон охидыг дотроос хамгийн ах настайгий нь.

ЭГШИГ хөг хөгжим, дуу аялгын зүйл; *хөгжмийн эгшиг; дууны эгшиг; эгшиг нийлүүлэн дуулах;* **эгшиг үсэг** (монголын цагаан толгойн А, И, О, Ө, У, Ү, Э авиаг тэмдэглэх үсэг); **эгшиг авиа** (өгүүлэхэд амны хөндийн дотор ямар ч хашилт саад үл тохиолдох авиа); **туслах эгшиг** (монгол цагаан толгойн Я, Ё, Ю, Ы, Е, Й энэ зургаа); **урт эгшиг** (Сунжруулж удаанаар хэлдэг эгшиг); **хос эгшиг** (хоёр өөр төрлийн эгшгээс нийлж нэг үеийг бүтээх эгшиг); **эгшиг зохицюх ёс** (үгийн тэргүүний үеийн эгшиг мөнхүү үгийн дараах үеийн эгшгийг ялган тогтоох ёс).

ЭГШИГЛҮҮЛЭХ эгшиглэхийн үйлдүүлэх хэв, эгшиглэхэд хүргүүлэх; *хөгжим эгшиглүүлэх.*

ЭГШИГЛЭХ аялуулах; *хөгжим эгшиглэх; эгшиглэн дуулах; эгшиглэх дуу сонсдов.*

ЭГШИГТ эгшиг бүхий юм: **эгшигт хайрцаг** пянзанд бичсэн дуу, хөгжим зэргийг хүч нэмэгдүүлэн эгшиглүүлэх хэрэгсэл); **эгшигт гийгүүлэгч** (ямагт эгшигтэй орох гийгүүлэгч).

ЭГШИХ нойтон юмны хатах, эврэх, хуурай болох; *норсон хувцас эгших.*

ЭГШРҮҮЛЭХ эгшрэхийн үйлдүүлэх хэв.

ЭГШРЭХ агшрах, эгших.

ЭГШҮҮЛЭХ эгшихийн үйлдүүлэх хэв, эгшихэд хүргүүлэх.

ЭГШҮҮН хуурай, агшуун.

ЭГШЭЭЛГЭХ эгшихэд хүргүүлэх, эгшүүн болгох.

ЭГШЭЭХ эгшихэд хүргүүлэх, эгшүүлэх.

ЭГЭВЧ хазгарын зуузайны гархинд торгосон ацтай гохт төмөр.

ЭГЭЛ энгийн, жирийн; *эгэл хүн; эгэл амьтан; эгэл болох; эгэл биш.*

ЭГЭЛДРҮҮЛЭХ эгэлдрэхийн үйлдүүлэх хэв.

ЭГЭЛДРЭГЛҮҮЛЭХ эгэлдрэглэхийн үйлдүүлэх хэв.

ЭГЭЛДРЭГЛЭХ 1. юм хумыг мөр тохойд өлгөх; *дээлээ эгэлдрэглэх;* 2. гараа хүзүүндээ уяж дүүжлэх; *гараа эгэлдрэглэх;* 3. ороомоглох; *бүсээ эгэлдрэглэх.*

ЭГЭЛДРЭХ I юмыг мөр, тохой зэргэтээ өлгөж хэдрэх; *эгэлдэрч үүрэх; эгэлдэрч чирэх.*

ЭГЭЛДРЭХ II урхидах, утас дээс зэрэг юмыг юманд өлгөж үзүүр этгээдийг гогцоонд оруулан татаж торгох.

ЭГЭЛТ буцалт, эргэлт, дахилт; *эгэлттэй хэрэг; эгэлтгүй явсан.*

ЭГЭМ хүн амьтны өнгөлүүрийн хоёр хажуугийн хөндлөн яс; *эгэм нь хугарах.*

ЭГЭМДЭХ барилдаж ноцолдоход эсэргүүцлийн эгмийн тус газраас барьж авах буюу дарж түлхэх; *эгэмлэж аваад эргүүлж мушгих.*

ЭГЭСХИЙХ 1. үйл хэрэгт урагш болохгүй, ухрах хойрголох; 2. баахан эгэх, буцасхийх.

ЭГЭСХИЙЧ эгэсхийх зантай хүн.

ЭГЭХ хойш буцах, эргэх; *нутагтаа эгэх.*

ЭГЭЭ I нэр мэдэхгүй хүнийг дуудахад гаргах аялга, хүн гуай гэсэн санаа.

ЭГЭЭ II арай; *эгээ үхсэнгүй; эгээ ийм байх ёсгүй; эгээ тийм биш ээ; манай зээрд азрага эгээ л түрүүлсэнгүй шүү.*

ЭГЭЭ III юманд унаж өвдөхөд сочин гаргах аялга.

ЭГЭЭЛ үнэхээр; *энэ эгээл сайн; энэ эгээл эрхэм.*

ЭГЭЭРЭЛ горилол, хүсэл, эрмэлзлэл, мөрөөдөл; **эгээрэл хүсэл, эгээрэл горилол, эгээрэл мөрөөдөл** х о р ш..

ЭГЭЭРЭХ горилох, хүсэх, мөрөөдөх, эрэх; *юмыг хэтэрхий эгээрэх хүсэхийн хэрэггүй.*

ЭГЭЭТЭЙ арай, арай л, золтой; *эгээтэй хоцорсонгүй; эгээтэй дарагдсангүй.*

ЭГЭЭХ юмны цухуйсан үзүүр мэтийг эргүүлж нугалан тогтоох; *хадаас эгээх.*

ЭД (ЭН) I заах төлөөний үг, энэ гэдгийн олон тоо; *эд явах уу? эд ямар зэрэг вэ? эднийд би өнөөдөр очив;* **эднийх** (ойр байгаа олон хүн амьтны юм).

ЭД II эдэлж хэрэглэж болох юм эдлэл; *эд хэврэг эээн мөнх* (дээл мялаахад хэлэх үг); **эд хогшил** (хүний хэрэглэх элдэв хэрэгсэл, ашиг хөрөнгө болгохоор хураасан хадгалсан мөнгө бараа зэргийн юм); **эд уурс** (эдэлж хэрэглэх бүх юмс; **эд уурсын зүйлс**); **эд юм** (эд уурс); **2. хүний эдэлж өмсөх** даавуу, торго бараа; *торгон эд; ноосон эд; даавуу эд; чанар сайтай эд байна; эдээр биеэ чимснээс, эрд-*

мээр биеэ чимсэн дээр х у у ч; **эд таваар** (эд бараа); **эд бараа** (хүмүүсийн хэрэглэх эдлэл ба барааны зүйлийн нэр): **эд хүргэх** (бусдад бэлэг тал болгож эд юм өгөх); 3. аливаа бодисын бүтсэн юм; *үүний чинь ямар эдээр хийсэн юм бэ?* 4. хувилахуй ухааны ёсонд нэг зүйлийн барамна; ☆ **эдийн засаг** (нийгэмлэгт нэёрхож байгаа үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэх хүчний хөгжлийн тухайн шатанд тохирч байгаа үйлдвэрлэлийн харьцааны цогц); **улс төрийн эдийн засгийн ухаан** (янз бүрийн нийгэмлэгийн үйлдвэрлэлийн арга нөхцөл хийгээд үйлдвэрлэлийн бүрэлдэхүүнээ хэрхэн хуваарилан солилцож байгааг судлах ухаан); **эд бөглөх** (хахуулилах, хахууль өгөх); **эд хонжих** (худалдаа гүйлгээний хонжлого буюу хүү хөлсийг илүү мэхлэн авах, бусдыг айлган хяхаж, хэтэрхий ашиг олж завших); **эд авах, эд жавших** (хахууль авах); **эдийн эзэн** (хулуугдсан юмны уг эзэн); **эд хуваах** (а. хүний эд хогшил зэргийг хуваалцах; б. хулгайн эд юмыг учир мэдэж хуваан авалцах; **эд бод хийх** (бүхэл бүтэн юмыг эвдэж хуваах).

ЭДГЭРҮҮЛЭХ эдгэрэхийн үйлдүүлэх хэв.

ЭДГЭРШ эдгэрэх, ялаарьших боломж.

ЭДГЭРШГҮЙ эдгэрэх шинж төлөвгүй; *эдгэршгүй хүнд өвчин; эдгэршгүй шарх*

ЭДГЭРЭЛ эдгэрэх үйлийн нэр; **эдгэрэл мод** у р г а м а л (байт цагаан модтой адил бөгөөд эргэн тойрон араатай навчтай нэгэн зүйл мод).

ЭДГЭРЭХ 1. аливаа өвчин эмгэг, шарх сорви аньж ялаарьших эдгэх; *өвчин эдгэрэх;* 2. ухэтгэсэн ургамлын сэхэж дахин сэргэх; *мод эдгэрэх; цэцэг эдгэрэх;* 3. хагалбарласан эвдэрсэн газрын битүүрч хэвтээ орох; *газар эдгэрэх; шуудуу эдгэрэх.*

ЭДГЭХ эдгэрэх, эрүүл болох, ялаарь болох.

ЭДГЭШ эдгэрш.

ЭДГЭШГҮЙ эдгэх, эдгэрэх шинж төлөвгүй.

ЭДГЭЭР биед ойр дөт байгаа олон юмыг хамтатган заах үг; *эдгээр хүмүүс; эдгээр юм.*

ЭДГЭЭХ эдгэхэд хүрүүлэх, эдгэрүүлэх.

ЭДЛҮҮЛЭХ 1. эдлэхийн үйлдүүлэх хэв; *унаа хөсөг эдлүүлэх;* 2. эдлэгдэх.

ЭДЛЭГДЭХ эдлэхийн үйлдэгдэх хэв.

ЭДЛЭГДЭХҮҮН эдлэгдэж байгаа бүх юм.

ЭДЛЭЛ хүний элдэв хэрэглэгдэхүүн зүйлийн нийт нэр; **эд эдлэл** х о р ш.; *мөнгөн эдлэл; хөвөн эдлэл; мяндсан эдлэл.*

ЭДЛЭХ 1. аливаа эд юмсыг ашиглан хэрэглэх; **эдлэх хэрэглэх** х о р ш.; *гэр эдлэх; газар эдлэх; машин техникийг гамтай эдлэх;* 2. амьтны хүч хөдөлмөрийг ашиглан хэрэглэх, *тэмээ эдлэх; эдлэхэд сайн морь;* 3. хүний ногдол үйлээ хүлээж байх; *ял эдлэх; зовлон эдлэх; үйлээ эдлэх;* 4. хууль ёсоор буюу үнэмлэх баримтаар олгогдсон эрхүүдийг заасан ёсоор хэрэглэх; *сонгууль эдлэх; сонгогдох эрхээ эдлэх.*

ЭДЛЭХҮҮН 1. эдлэл; 2. эзэмшил; *помещикийн эдлэхүүн газар.*

ЭДЭЛБЭР эзэмшил; эдэлгээ; *эдэлбэр газар; эдэлбэр сайтай.*

ЭДЭЛГЭЭ эд юмны чанар байдал; *эдэлгээний чанар; эдэлгээ сайтай; эдэлгээ муутай.*

ЭДМЭГ эцэж зүдэрсэн малд өгөх амуу тарианы зүйлийн чанамал тэжээл; *эдмэгээр мал тэжээх;* **эдмэг боорцог** (монгол амуугийн нухамшийн жигнэмэл гурил).

ЭДМЭГРЭХ эдмэртэх; *дээлийн хажлага эдмэгэрч байна.*

ЭДМЭГШИХ эдмэрших, эдмэгрэх шинж орох.

ЭДМЭРТЭХ зөөлөн эдлэлийн элэгдэж хэврэгших, сэмрэх.

ЭДМЭРШИХ эдмэртэх шинж орох.

ЭДНИЙХ (ЭН) эд гэдэг заах төлөөний үгийн хамаадуулах хэлбэр; *эднийхэн өнөөдөр хааш нүүв?*

ЭДҮҮГЭЭ сдоо; *эрт эдүүгээ.*

ЭДҮҮЛБЭР юмны эхлэл, эхэлбэр.

ЭДҮҮЛБЭРЛЭХ эхлэх, үүсэх.

ЭЕ I 1. эв, зүй; **эе эв, эе зүй** х о р ш.; 2. нийлэмж, зохимж, зохис; **эе нийлэмж, эе зохис** х о р ш.; **эеэр** (сэтгэлд зохистой сайнаар тохирсны нь; *эеэр бүтэв; эеэр зохицов).*

ЭЕ II х у у ч и р с а н төрсөн эх.

ЭЕВРЭГ сэтгэлд нийлэмжтэй, зохистой, эелдэг, эевэргүү, эерэг ч гэдэг; *энэ хир эрхмийн эрхэлсэн үйл ажил таалалчлан эеврэг зэргийг юун лавлах ажээ.*

ЭЕВЭРГҮҮ эеврэг, эерэг.

ЭЕГҮЙ эвгүй, зүйгүй, зохисгүй, нийлэмжгүй, зохимжгүй, эелдэг биш.

ЭЕДЭХ 1. зөөлрөх, сулрах, хөнгөрөх; **эедэх аядах** х о р ш.; *цаг эедэж байна; өвчин эедэж байна;* 2. бусдын санаанд тохируулан нийцэх.

ЭЕЛДЭГ 1. зан байдал эетэй нийлэмж сайтай; **эелдэг зөөлөн** х о р ш; *эелдэг зан гаргах; эелдэг бүсгүй;* 2. эдлэх хэрэглэхэд илбэрүүхэн эвтэй юм.

ЭЕЛҮҮЛЭХ эелэхийн үйлдүүлэх хэв.

ЭЕЛЭЛ 1. эелэх үйлийн нэр; 2. эвлэл; **эелэл эвлэл** х о р ш.; 3. зүй зохис, эе эв.

ЭЕЛЭХ 1. юмны үс ширхгийг эелдэг болгож засах; 2. эе эвийг олох, зүй зохисы нь олох; **эелэх эвлэх** х о р ш.; 3. аялах, аргадах, нийцэх, зохицох; **эелэх аялах** х о р ш..

ЭЕР I 1. загасны гэдсэнд наалдаж төрсөн цагаан юм; 2. морин мэлхийн доторхи өөх.

ЭЕР II 1. амьтны идээ хоолны элбэгт ханаж булилан өегшсөний нь; ир ч гэдэг; *эертэй болсон хүн; эер нь ханасан хүүхэд;* 2. идээний амтлаг шандуурам чанар.

ЭЕРЭГ эетэй, нийлэмжтэй, зохистой, тохиромжтой.

ЭЕТЭЙ аятай, эвтэй, зохистой, нийлэмжтэй, таатай, тааламжтай.

ЭЖ эх, ээж ч гэнэ; *төрсөн эж; эмэг эж.*

ЭЖГИЙ гэнт эндэгдсэн алдагдсан газарт гомдож гаргах аялга.

ЭЖИЙ эж, ээж.

ЭЖҮҮХИЙ I бага хүүхдийг аргадахад хэрэглэх аялга, сайхан гэсэн санаа.

ЭЖҮҮХИЙ II: **эжүүхий хажуухай** маш бяцхан юм.

ЭЗ муу тохиол ирэхийн өмнөхөн тохиолдох сайн тохиол; *эзтэй халуун байна, бороо орох магадгүй байх; энэ өдөр эзтэй эрхэлж байна, маргааш юу болох бол доо!* **эз нь хатгах, эз нь ирэх, эз нь татах** (ямар нэгэн муу тохиол болохыг болгоомжлохгүй мэтээр үл сэрэмжлэх буюу нэн ч түүний нөхцөлийг угтан үүтгэх; *чи маргааш үйлах гэж энэ өдөр эз чинь хатгасан биш биз ээ);* **эз дийлэх** (бусдыг эрх хүчээр түрэмгийлэх, эзэрхэх).

ЭЗГҮЙ эзэнгүй, газар нутаг гэр орон зэрэгт хүнгүй чөлөө цаг үес; *гэрийн эзэн эзгүй байна, эзгүй хойгуур; эзгүй хооронд.*

ЭЗГҮЙДҮҮЛЭХ эзгүйдэхийн үйлдүүлэх хэв.

ЭЗГҮЙДЭХ хэтэрхий эзгүй болох, эзэнгүй учраас аюул хөнөөл болох; *мал эзгүйдээд шуурганд урууджээ.*

ЭЗГҮЙРҮҮЛЭХ эзгүйрэхийн үйлдүүлэх хэв.

ЭЗГҮЙРЭХ газар орон зэрэгт эзэнгүй болох.

ЭЗГҮЙЧЛҮҮЛЭХ эзгүйчлэхийн үйлдүүлэх хэв.

ЭЗГҮЙЧЛЭХ бусдын эзгүй чөлөө цагийг завшин хэрэглэх.

ЭЗЛҮҮЛЭХ 1. эзлэхийн үйлдүүлэх хэв; 2. эзлэгдэх.

ЭЗЛЭГДЭХ эзлэхийн үйлдэгдэх хэв.

ЭЗЛЭХ 1. юманд эзэн болох, эзэмших, эзэрхэх; *улс орныг эзлэх; айл гэрийг эзлэх; эд хөрөнгийг эзлэх;* 2. юмны зай завсрыг ашиглах, хэрэглэх; *гэр оромжийн зайг эзлэх; сав сууглын зай эзлэх; гурван метр талбай эзлэх;* 3. уралдаан тэмцээн зэрэгт сууринд орох; *уралдаан тэмцээнд байр эзлэх; нэгдүгээр байр эзлэх.*

ЭЗТЭЙ эз бүхий, сайн биш, дэндүү, хэтэрхий; *эзтэй халуун өдөр; эзтэй дүрсгүй хүүхэд; эзтэй хулгайч муур.*

ЭЗШИХ эзэмших, эзэмдэх.

ЭЗЭГНҮҮЛЭХ эзэгнэхийн үйлдүүлэх хэв.

ЭЗЭГНЭХ эзэн болох, эзэмдэх, эзэмших.

ЭЗЭЛГҮЙ эзэгүй.

ЭЗЭМДҮҮЛЭХ эзэмдэхийн үйлдүүлэх хэв.

ЭЗЭМДЭХ эзлэх, эзэрхэх, эзэмших.

ЭЗЭМШИГДЭХ эзэмшихийн үйлдэгдэх хэв.

ЭЗЭМШИЛ 1. эзэмших үйлийн нэр; *эзэмшлийн газар; эзэмшил хөрөнгө;* 2. цэргийн хүчээр бусдын газар нутгийг эзэмшсэн эзэмдэл; *эзэмшлийн цэрэг; эзэмшлийн дэглэм; эзэмшлийн бүс.*

ЭЗЭМШИХ 1. юманд эзэн болох, эзлэх, эзэмдэх; *өв хөрөнгө эзэмших; алдуул хэл эзэмших; атар газар эзэмших;* 2. аливаа юмыг ашиглаж чадах, ашиглаж сурах; *марксизм ленинизмийг бүтээлчээр эзэмших; шинэ сууль машиныг эзэмшиж ажиллуулах; бэвсэг эзэмших;* **гадаад хэл эзэмших** (гадаад хэлээр чөлөөтэй ярьж бичиж сурах).

ЭЗЭМШҮҮЛЭХ 1. эзэмшихийн үйлдүүлэх хэв; 2. эзэмшигдэх.

ЭЗЭН 1. ямар нэгэн юмыг бүрэн эрхтэйгээр эзэмших эрхийг эдэлсэн хүн; *гэрийн эзэн; үйлдвэрийн эзэн; малын эзэн; үйлийн эзэн; хэлсэн үгэндээ эзэн болж, идсэн хоолондоо сав болох* х у у ч; **эзэн суух** (юманд эзэн нь би гэж эзэрхэх; *хүний юманд эзэн суух);* **эзэн суулгах** (өөрийн юмыг бусдад эзэмшүүлж эзэн болгох); **үйлдвэрийн эзэн** (капиталист үйлдвэрийн газрын эзэн этгээд, мөлжигч; *ажилчдаас ажлын цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар үйлдвэрийн эзэнд шаардлага тавих);* **газрын эзэн** (феодалын байгуулал, хамжлага бүхий газар оронд байдаг газар эзэмшигч этгээд; *газрын эзний газрыг хураан авч улсын болгох);* 2. хаант засагт улсад хааныг нэрлэх нэр; *эзэн хаан.*

ЭЗЭНГҮЙ 1. эзэн нь байхгүй, эзэн болох хүнгүй; 2. хүн амьтангүй, зэлүүд газар; *эзэнгүй газар.*

ЭЗЭНТ эзэн хаан бүхий; *эзэнт улс.*

ЭЗЭНТЭЙ 1. эзэн бүхий; *эзэнтэй айл; эзэнтэй мал; буух эзэнтэй, буцах замтай;* 2. хүн амьтны оршин суудгий нь; *эзэнтэй нутаг.*

ЭЗЭРХҮҮЛЭХ эзэрхэхийн үйлдүүлэх хэв.

ЭЗЭРХЭГ бусдыг түрэмгийлэн эзэрхэх дарлах зан аалитайгий нь; **эзэрхэг харгис, эзэрхэг түрэмгий** х о р ш..

ЭЗЭРХЭГЛЭХ эзэрхэг зан ааль гаргах.

ЭЗЭРХЭХ бусдыг түрэмгийлэн эзлэх, эзэмших; *улс орныг эзэрхэх; айл гэрийг эзэрхэх; эзэрхэн булаах.*

ЭЗЭЭГҮЙ аргагүй, эрхгүй, эзэнгүй ч гэдэг; *энэ номыг би өөрөө хэрэглэх гэсэн юм, эзээгүй танд л гэж өгье; би түүнийг авъя гэсэн, эзээгүй хүч үл хүрэх тул болив.*

ЭЗЭЭНГҮЙ эзээгүй.

ЭКРАН дэлгэц; *киноны экран.*

ЭКСКУРС алив юмыг үзэж сонирхох зэргээр хамт олноороо явах аялал; *экскурс хийх; экскурсээр явах.*

ЭКСПЕДИЦ 1. тусгай зорилгоор хэсэг бүлэг хүмүүс явах аялал; *экспедицийн бүрэлдэхүүн; экспедицид оролцон явах;* 2. хээрийн шинжилгээний анги; *экспедицийн урьдчилсан тайлан гаргах; эрдэм шинжилгээний экспедиц.*

ЭКСПОРТ гадаадад гаргах юм; *экспортод гаргах.*

ЭКСПОРТЛОХ экспортод гаргах.

ЭКСПОРТЛУУЛАХ экспортлохын үйлдүүлэх хэв.

ЭЛ I бүгд, байгаа бүх; *авдар саванд байгаа эл юм; газрын хөрсөнд байгаа эл баялаг.*

ЭЛ II энэ; *эл хэрэг; эл зүйл.*

ЭЛ III у р г а м а л халуун оронд ургадаг гаагийн язгуурын нэгэн зүйл ургамал, үрийг хоол амтлахад хэрэглэнэ.

ЭЛ IV: **эл эсгүй** ураг удамдаа элэгсэггүй; ☆ **эл харш** (тааламжтай, тааламжгүй, сайн муу): **эл дайсан** (янаг ба өшөөтөн).

ЭЛБЭГ 1. үлэмж их; **элбэг дэлбэг** х о р ш.; *элбэг хоол; аргал элбэг газар; элбэг баян айл гэр мал элбэг орон;* 2. дээл хувцасны уужим урт; *элбэг дээл; элбэг цамц.*

ЭЛБЭГГҮЙ их биш, бага, ховор, дутмаг.

ЭЛБЭГДҮҮЛЭХ элбэгдэхийн үйлдүүлэх хэв, ихдүүлэх.

ЭЛБЭГДЭХ хэтэрхий элбэг, их учраас тохиромжгүй болох; *юм элбэгдэх; хувцас элбэгдэх.*

ЭЛБЭГЖИХ элбэг, их болох; *бараа таваар элбэгжиж байна.*

ЭЛБЭГЖҮҮ юмны элбэг хүрэлцээтэй байгаагий нь; *элбэгжүү айл; элбэгжүү зан.*

ЭЛБЭГЖҮҮЛЭХ элбэгжихийн үйлдүүлэх хэв, элбэг их болгох.

ЭЛБЭГТЭЙ элбэг бий, их; *ус элбэгтэй худаг; мод элбэгтэй нутаг; сааль элбэгтэй айл.*

ЭЛБЭГШИХ элбэг шинжтэй болох.

ЭЛБЭГШҮҮЛЭХ элбэгшихийн үйлдүүлэх хэв.

ЭЛБЭДЭН а м ь т а н янз байдал элбэнхтэй адил, хүн шиг нүдтэй нэгэн зүйл гөрөөс.

ЭЛБЭНХ а м ь т а н 1. үнэгтэй адилхан, өнгө харавтар болоод шархан нэг зүйл үслэг ан, илбэнх өлбөнх ч гэдэг; 2. мөнхүү амьтны үсээр хийсэн эдлэл; *элбэнх дээл.*

ЭЛБЭРҮҮЛЭХ 1. элбэрэхийн үйлдүүлэх хэв; 2. элбэрэгдэх.

ЭЛБЭРЭГДЭХ элбэрэхийн үйлдэгдэх хэв.

ЭЛБЭРЭЛ элбэрэх үйлийн нэр; **ачлал элбэрэл** х о р ш.. -ᠠᠴᠢᠯᠠᠯ ᠡᠯᠪᠡᠷᠡᠯ

ЭЛБЭРЭЛТ ачлалт; *элбэрэлт эжий.* -ᠠᠴᠢᠯᠠᠯᠲᠤ ᠡᠵᠡᠢ

ЭЛБЭРЭНГҮЙ элбэрэх үйлийг зөв сайн гүйцэтгэгч; **элбэрэнгүй энэрэнгүй** х о р ш.; *элбэрэнгүй хүн.* -ᠠᠴᠢᠯᠠᠭᠴᠢ ᠡᠨᠡᠷᠡᠨᠭᠦᠢ ᠬᠦᠮᠦᠨ

ЭЛБЭРЭХ эцэг эх, төрөл ургаа зохистойгоор хүндэтгэн үйлчлэх. -ᠠᠴᠢᠯᠠᠬᠤ

ЭЛБЭХ үйл ажлыг хавсах, хамжин гүйцэтгэх; **элбэх дэлбэх, элбэх хамжих** х о р ш.; *элбэж хийх; бүгдээрээ элбэж дэлбэж байгаад л энэ ажлыг дуусгая.* -ᠠᠴᠢᠯᠠᠬᠤ

ЭЛГЭВЧ элэгний этгээдээс даарах хөрөхийг хамгаалж өмсөх нэгэн зүйл хувцас; зарим газар бэлхэвчийг ч элгэвч гэдэг. -ᠡᠯᠭᠡᠪᠴᠢ

ЭЛГЭВЧЛЭХ элгэвч өмсөх. -ᠡᠯᠭᠡᠪᠴᠢᠯᠡᠬᠦ

ЭЛГЭГ юмыг нарийлан шигших шигшүүр; **элгэг шигшүүр** х о р ш.. -ᠡᠯᠭᠡᠭ

ЭЛГЭГДЭХ элгэг шигшүүрээр нарийлан шигших. -ᠡᠯᠭᠡᠭᠳᠡᠬᠦ

ЭЛГЭМСЭХ төрөлсөх, төрхөмсөх, дотнод үзэх. -ᠡᠯᠭᠡᠮᠰᠡᠬᠦ

ЭЛДҮҮЛЭХ 1. элдэхийн үйлдүүлэх хэв; 2. элдэгдэх. -ᠡᠯᠳᠦᠦᠯᠡᠬᠦ

ЭЛДҮҮР I арьс шир зэрэг юмыг элдэхий нь; *элдүүр сайтай; элдүүр муутай; гар элдүүрийн арьс.* -ᠡᠯᠳᠦᠦᠷ

ЭЛДҮҮР II гурил элдэх хүвэр мод; зарим газар ганжин, гулууз ч гэдэг; *элдүүр мод.*

ЭЛДҮҮРЧ (ИН) арьс шир зэргийг элдэхэд чадамгай хүн. -ᠡᠯᠳᠦᠦᠷᠴᠢ

ЭЛДЭВ зүйл зүйлийн, янз янзын, төрөл бүрийн; **элдэв шалдав, элдэв хангай** х о р ш.; *элдэв амьтан; элдэв хувцас; элдэв таваар; элдэв өнгө;* **элдэв эсийн** (элдэв бүсын, янз бүрийн): **элдэв бүсын** (зүйл зүйлийн сайн муу, янз бүрийн юм холилдсоны нь; *элдэв бүсын юм; элдэв бүсын амьтан);* **элдэв зүйл** (олон зүйл); **элдэв янз** (янз янз, зүйл зүйл); **элдэв гуухай** (элдэв шалдав, өнгийн хангайн); **элдвийг үзэх** (амал зовнил сольцон тохиолдох зэрэг зүйл зүйлийн тохиол учрал үзэж өнгөрүүлэх); **элдвий нь үзэх** (а. хүн амьтныг зовоох буюу зовоох амуулахыг хольцуулан эдлүүлэх; б. эд бодисыг үйлдэх засахын зэрэгт зүйл зүйлээр урвуулан хөрвүүлэн оролдох): **элдвээр** (зүйл зүйлээр, янз янзаар, элдэвчлэн; *элдвээр оролдох; элдвээр аашлах).* -ᠡᠯᠳᠡᠪᠦᠷ

ЭЛДЭВЛҮҮЛЭХ элдэвлэхийн үйлдүүлэх хэв. -ᠡᠯᠳᠡᠪᠯᠦᠦᠯᠡᠬᠦ

ЭЛДЭВЛЭХ 1. өөр бусдыг туслах хөнөөх зэрэгт зүйл зүйлийн арга мэх үүсгэх; 2. юмны зүйл зүйлээр хувирах өөрчлөх, тогтворгүй болох; **элдэвлэвч** (зүйл зүйлээр оролдовч; *элдэвлэвч үгэнд орсонгүй; элдэвлэвч бүтсэнгүй).* -ᠡᠯᠳᠡᠪᠯᠡᠪᠴᠢ

ЭЛДЭВТЭЙ арга ов, заль мэх ихтэй, зан байдал хувирамтгай; *элдэвтэй хүн.* -ᠡᠯᠳᠡᠪᠲᠡᠢ ᠬᠦᠮᠦᠨ

ЭЛДЭВЧЛҮҮЛЭХ элдэвчлэхийн үйлдүүлэх хэв. -ᠡᠯᠳᠡᠪᠴᠢᠯᠡᠬᠦ

ЭЛДЭВЧЛЭХ элдэвлэх, зүйл зүйлээр үзэх. -ᠡᠯᠳᠡᠪᠴᠢᠯᠡᠬᠦ

ЭЛДЭГНЭХ арьс шир, цаас бөс зэргийн юм баахан элдэгдэж нухлагдан зөөлрөсхийх. -ᠡᠯᠳᠡᠭᠨᠡᠬᠦ

ЭЛДЭНШИХ элдэгдэж зөөлрөх; *арьс элдэнших.* -ᠡᠯᠳᠡᠨᠰᠢᠬᠦ

ЭЛДЭХ I 1. хатуу хөшүүн юмыг зөөлрүүлэх эелүүлэх, уян зөөлөн болгох; *арьс шир элдэх; гурил элдэх;* 2. бусдыг жанчих; **элдэх шүү** (арьс элдэхэд хэрэглэдэг, байван мэт нэг зүйл шүү). -ᠡᠯᠳᠡᠬᠦ

ЭЛДЭХ II үлдэн хөөх, хөөцөлдөх; *мориор элдэх; элдэн хөөх.*

ЭЛЕКТРОН өчүүхэн төдий сөрөг цахилгаан цэнэг бүхий хэсэг; *электрон физик.* -ᠡᠯᠡᠺᠲᠷᠣᠨ

ЭЛЖИГ (ЭЛЖГЭН) адууны язгуурын нэг зүйл амьтан, адуунаас биеэр бага, чих урт, толгой том, унаж эдэлж болно; *элжиг хударгандаа тохирно* з ү й р; *элжигний чихэнд алт хийвч сэгсэрнэ, аргал хийвч сэгсэрнэ* з ү й р; **элжгэн чих** у р г а м а л (модонд ургадаг, өнгө шар, амт амтайхан жимс, зүйл маш олон); **элжгэн чихэн цэцэг** у р г а м а л (модорхог иштэй, элжгэн чихтэй адил навчтай, өнгө нь шар сундуутай, цагаан цэцэгтэй, өвөл цэцэглэдэг дөрвөн улиралд шарладаггүй нэгэн зүйл цэцэг); -ᠡᠯᠵᠢᠭ

ЭЛЖИМЧ а м ь т а н янз өнгө самжийн адил болоод элжиг мэт том, өндөр модонд авирахдаа сүрхий нэгэн зүйл сармагчин. -ᠡᠯᠵᠢᠮᠴᠢ

ЭЛЖИН халим загасны сахал. -ᠡᠯᠵᠢᠨ

ЭЛИЙ: элий балай ухаан бодол гэмтэж муудан юмыг мэдэх эсэхийн төдийд хүрсэн байдал; *элий балай болох.* -ᠡᠯᠢᠢ

ЭЛИЙРЭХ элий балай болох. -ᠡᠯᠢᠢᠷᠡᠬᠦ

ЭЛИЙХ элийрэх. -ᠡᠯᠢᠢᠬᠦ

ЭЛМЭГ 1. мал адгуусны эдэлгээ ажиллагаа огт сураагүй атар долгины нь, эмнэг ч гэнэ; 2. хүний юм үзэж нүд тайлж, ухаан санаа нээгдээгүй мохоо доройгий нь; *элмэг хүн.* -ᠡᠯᠮᠡᠭ

ЭЛМЭГДЭХ хэтэрхий элмэг болох.

ЭЛМЭГРЭХ элмэг байдалтай болох

ЭЛМЭГШИХ адуу малын унамгай номхноо мартаж догшрох, хүдхрэх.

ЭЛМЭРҮҮ ухаан мэдрэл нэгэнт муудсаны нь; *элмэрүү хүн.*

ЭЛМЭРЭХ 1. ухаан мэдрэл муудах, эргүү болох; 2. үйл юмыг хэрхэхийн учрыг мэдэхгүй гайхах; **элмэрэх гайхах** х о р ш..

ЭЛС (ЭН) үүрэм шороогоос бүдүүн ширхэгтэй хатуу чулуулаг; *элсэн чулуу; элсэн шороо; элсэн ширхэг;* **элс манх** (элс ихээр хуралдаж, уул овоо мэт цогцлон тогтсоны нь); **элсэн шуурга** (элсээр шуурах шуурга); ☆ **элсэн чихэр** (элс мэт жижиг талст чихэр).

ЭЛСДЭХ хэтэрхий элс болох.

ЭЛСЛЭХ элсий нь цэвэрлэх, арилгах.

ЭЛСРЭХ элс мэт болох.

ЭЛСТ элс бий; *элст толгой.*

ЭЛСТЭЙ элс бүхий; элс ихтэй; *их элстэй газар.*

ЭЛСҮҮЛЭГДЭХ элсүүлэхийн үйлдэгдэх хэв.

ЭЛСҮҮЛЭЛТ элсүүлэх үйлийн нэр.

ЭЛСҮҮЛЭХ 1. элсэхийн үйлдүүлэх хэв; *намд элсүүлэх; ажилчин элсүүлэх;* 2. элсэх.

ЭЛСЭГ ураг удам, нөхөр ханьдаа амраг элэгсэг сэтгэлтэй.

ЭЛСЭГДЭХ элсэхийн үйлдэгдэх хэв.

ЭЛСЭГЛЭХ амраг элсэг байдал гаргах.

ЭЛСЭГЧ элсэж байгаа этгээд.

ЭЛСЭЛТ элсэх үйлийн нэр; *дээд сургуулийн элсэлт; элсэлтийн шалгалт.*

ЭЛСЭНЦЭР ихээхэн элстэй хөрс; *элсэнцэр хөрс.*

ЭЛСЭРХҮҮ 1. элс ихтэй; 2. элс мэт байдалтай.

ЭЛСЭРХЭГ элсэрхүү.

ЭЛСЭХ аливаа байгууллага, сургуульд сайн дураар орох, түүнд орсонд тооцогдох; *намд элсэх; гишүүнд элсэх; нэгдэлд элсэх; ажилд элсэх; сургуульд элсэн оров.*

ЭЛТ хүч нэмэгдүүлэх үг; *элт цохих; элт үсрэх; элт татах.*

ЭЛТЛҮҮЛЭХ 1. элтлэхийн үйлдүүлэх хэв; 2. элтлэгдэх.

ЭЛТЛЭХ I элтрэхэд хүргүүлэх, элтргүүлэх, хэлтлэх, **элтлэх хэлтлэх** х о р ш..

ЭЛТЛЭХ II юмыг хөндлөн гулд сүлжих.

ЭЛТРҮҮЛЭХ элтрэхийн үйлдүүлэх хэв, элтрэхэд хүргүүлэх.

ЭЛТРЭХ хэлтрэх, холтрох, эмтрэх, ховхрох; *будаг нь элтрэх; шаазангийн ам элтрэх.*

ЭЛТЭРХИЙ хэлтэрхий, сэлтэрхий, эмтэрхий; **элтэрхий хэлтэрхий** х о р ш..

ЭЛҮҮ томоохон амьтны орших орогнох нүх цооног; *тарваганы элүү; үнэгний элүү.*

ЭЛҮҮЛЭХ 1. элэхийн үйлдүүлэх хэв, элээх; 2. элэгдэх.

ЭЛХЭГ элгэг.

ЭЛХЭГДҮҮЛЭХ элхэгдэхийн үйлдүүлэх хэв.

ЭЛХЭГДЭХ элхэг шиг шүүрээр юмыг нарийлан шигших.

ЭЛЧ I албан газраас гадагш томилон зарагдсан албаны хүн; *шуудан хүргэгч элч; элчийн уналга.*

ЭЛЧ II 1. материйн хөдөлгөөний онцгой хэлбэр болох аливаа бодисын хэсгүүдийн хөдөлгөөнөөс үүсэх эрчим; *нарны элч; галын элч;* 2. амьтны биеийн халуун хувь.

ЭЛЧИЛГҮЙ зэлүүд, хүнгүй; *элчилгүй говь; элчилгүй элс.*

ЭЛЧИН нэгэн улсаас нөгөө улсад улсаа төлөөлж суулгасан бүрэн эрхт төлөөлөгч; *элчин төлөөлөгч;* **элчин сайд** (улсаа төлөөлж харь улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн албан тушаал; *онц бүрэн эрхт элчин сайд);* **элчин сайдын яам** (а. элчин сайдаар толгойлуулсан дипломат төлөөлөгчийн газар; б. мөн тийм албан газрын байшин барилга); **элчингийн газар** (элчин сайдын яам).

ЭЛЧИТ элч бий; *элчит түлш; элчит тэрэг; элчит тэрэгний машинч.*

ЭЛЧТЭЙ элч бүхий юм; *их элчтэй нүүрс.*

ЭЛЭГ (ЭЛГЭН) I 1. хүн амьтны уушигны дор, өрцөд наалдаж тогтсон сөс боловсруулах нэгэн цулын нэр; **элэгний өвчин** (элэг үрэвсэх өвчин); **элгээ тэврэх** (хоёр гараа өвчүү ойсын тус барилдуулах); **элгээ эвхэх** (даарах, бие чилэх, залхуу хүрэх зэрэгт мөр хумьж тол-

гой дарах); **элгэн өнгө** (улаан бараан хоёр тэгш хольцонгуй өнгө); **элгэн тараг** (сая бүрэлдээд хутгагдаагүй зайлагдаагүй байгаа тараг); ☆ **элэг эмтрэх** (өр өвдөх, сэтгэл ихэд гащуудан тэсхүйеэ бэрх болох); **элэг хөших, элгээ хөштөл инээх** (тэсч ядталаа инээж элэгний тус аягүй болох); **нумны элэг** (нумны дүгрэглэн матирах тал); 2. ш и л ж с э н садан төрөл; **элгэн төрөл** (төрөл садан); **элэг хатах** (а. тусгаар байгаа хүүхэд, эцэг эх зэргээ эгээрэн санагалзаж хэнээрэх; б. ихэд цангах); **элэг татагдах** (ураг төрлийн хүмүүсийн төлөө зовниж, больё гэсэн ч больж чадахгүй байх); **элэг татуу** (ураг төрөл, овог салааны хүнийг хэтэрхий дотночлон өмгөөлөхий нь); **элэг татах** (а. төрөл ураг, аймаг үндсээ дотночлон үзэх: б. нумны хөвчний этгээд дүгрэглэн матирах газарт эвэр нийлүүлж наах; в. элэгний тус газар таталдан өвдөх, цорой татах ч гэнэ); **элгэн хад** (ханан хад, өндөр цавчим гилгэр хад). -ᠡᠯᠡᠭ

ЭЛЭГ II доог; **элэг доог** х о р ш.; **элэг доог хийх, элэг доог болгох** (бусдыг доромжлон элэглэх ба хошигнож наадах): **элэг барих** (бусдыг дор үзэж доог хийн дээрэнгүйлэх, дарлах). -ᠡᠯᠡᠭ

ЭЛЭГДЭЛ элэгдэх үйлийн нэр; **элэгдэл хорогдол** х о р ш.. -ᠡᠯᠡᠭᠳᠡᠯ

ЭЛЭГДЭХ I элэхийн үйлдэгдэх хэв; *хувцас элэгдэх.* -ᠡᠯᠡᠭᠳᠡᠬᠦ

ЭЛЭГДЭХ II арьсыг идээлж боловсруулахын тул элгийг няцчин зуурч түрхэх; *арьс элэгдэх.* -ᠡᠯᠡᠭᠳᠡᠬᠦ

ЭЛЭГЛҮҮЛЭХ 1. элэглэхийн үйлдүүлэх хэв; 2. элэглэгдэх. -ᠡᠯᠡᠭᠯᠦᠭᠯᠡᠬᠦ

ЭЛЭГЛЭГДЭХ элэглэхийн үйлдэгдэх хэв. -ᠡᠯᠡᠭᠯᠡᠭᠳᠡᠬᠦ

ЭЛЭГЛЭЛ бусдыг басамжлан доромжилж шоолох, доог тохуу хийхий нь. -ᠡᠯᠡᠭᠯᠡᠯ

ЭЛЭГЛЭХ I 1. хүүхэд багачуудын мөлхөж эхлэхийн урьд элгээр гулгалхийлан явах ба хүн, элгээр гулгалхийлан гэтэх буюу мяраах; 2. хүний түрүүлгээ харж элгээр юмыг дарах ба элгэнд тулгаж юм түлхэх үйлдэх; 3. мал адгуусны шинэ ногоонд цадаж элэг нь амт орж том болох; 4. зарим юмны элэгрэх; *цавуу элэглэх; зуурсан шавар элэглэх;* **нум элэглэх** (нумны элгэнд эвэр зүйж наах). -ᠡᠯᠡᠭᠯᠡᠬᠦ

ЭЛЭГЛЭХ II 1. юмыг дууриан аашлах; *элэглэн дууриах;* 2. бусдыг басамжлан доромжлох мэтээр шоолох, дооглох. -ᠡᠯᠡᠭᠯᠡᠬᠦ

ЭЛЭГЛЭХ III элэгдэх II.

ЭЛЭГРЭХ элэг шиг байдалтай болох; *цус элэгрэх; тараг элэгрэх.* -ᠡᠯᠡᠭᠷᠡᠬᠦ

ЭЛЭГСЭГ дотно, амраг элсэг; *уулзалт их л элэгсэг найртай болж өнгөрөв.* -ᠡᠯᠡᠭᠰᠡᠭ

ЭЛЭГСЭХ дотнолох, янаглах, дөтлөх. -ᠡᠯᠡᠭᠰᠡᠬᠦ

ЭЛЭГТЭЙ бусдад найз элэгсэг дотно зантай; *зөв элэгтэй; буруу элэгтэй;* **хар элэгтэй** (төрөл биш). -ᠡᠯᠡᠭᠲᠡᠶ

ЭЛЭГШЭЭЛГЭХ элэгшээхэд хүргүүлэх. -ᠡᠯᠡᠭᠰᠡᠭᠰᠡᠭᠦᠯᠬᠦ

ЭЛЭГШЭЭХ элэгсэх, элгэмсэх, янаг сэтгэлээр хайрлах. -ᠡᠯᠡᠭᠰᠡᠭᠦᠯᠬᠦ

ЭЛЭН: элэн хулин чимээ анир, үймээн шуугиангүй нам гүм. -ᠡᠯᠡᠨ

ЭЛЭНГЭ хуучран үлтэрсэн, муудсан юм. -ᠡᠯᠡᠩᠭᠡ

ЭЛЭНХИЙ эд юмны элэгдэж үлтрэн муудсаны нь. -ᠡᠯᠡᠩᠬᠢᠶ

ЭЛЭНХИЙТЭХ юмны энд тэндээ элэнгэ болох. -ᠡᠯᠡᠩᠬᠢᠶᠲᠡᠬᠦ

ЭЛЭНЦ өвгийн эцэг эх; **элэнц өвөг** (төрсөн өвгийн эцэг); **элэнц эцэг** (элэнц өвөг); **элэнц эмэг** (төрсөн өвгийн эх). -ᠡᠯᠡᠨᠴ

ЭЛЭНЦЭГ элэнц. -ᠡᠯᠡᠨᠴᠡᠭ

ЭЛЭХ I 1. эд юмны хуучрах, үлтрэгдэх, хорогдох, нимгэрэх, цоорох, урагдах; 2. юмыг хальчин нүхлэх огтлох. -ᠡᠪᠡᠬᠦ • -ᠡᠯᠡᠬᠦ

ЭЛЭХ II халих; **элэх халих** х о р ш.; *агаарт элэн халин нисэх.*

ЭЛЭЭ а м ь т а н шонхрын нам, улайд дургай, жижиг амьтад ба шувууны ангаахай хорхой шавьж идэж амьдардаг нэгэн зүйл махчин шувуу; *тэр эргэн дээгүүр элээ хэрээ галуу гурав эргэж байна* (хэл зүгшрүүлэх үг); **элээ үнэг** а м ь т а н (мөрөн тэнгэст орших лаг мэлхийтэй адилавтар нэгэн зүйл хорхой, сүүдэр харвагч хорхой ч гэдэг); **элээ хар** у р г а м а л (байдал усан хоногийн адил болоод саравгар түрүүтэй нэгэн зүйл өвс). -ᠡᠯᠡᠭ ᠭ

ЭЛЭЭХ элэхэд хүргүүлэх, элүүлэх, юмыг хуучруулах, элэгдүүлэх; *гутлаа элээх.* -ᠡᠯᠡᠬᠦ

ЭМ I 1. эр гэдгийн эсрэг утга, эр биш бэлэг бүхийгий нь; *эм хонь; эм ямаа; эм гахай;* **эр эм хоёр** (нөхөр гэргий хоёр); **эр эм болох** (гэрлэх, ураг холбох): **эм зан** (эрэгтэй хүний зан ааль, авир ааш нь эмэгтэй хүний байдалтай); **эм дэгээ** (барилдахад эсэргүүцлийн хөлийн гадуур нэг хөлөөр дотогш, гохдон хийх нэгэн зүйл мэх); **эм шилбэ** (товчийг торгох шилбэ, эм товч ч гэдэг); **эм эрэг** (шураг шургуулж эрэгдэх эрэг); ☆ **эм домоо** у р г а м а л (өнгө үүрд ногоон, өндөр нь 25—30 тохой хир-

халуун оронд ургадаг нэгэн зүйл мод); 2. х у у ч и р с а н насанд хүрсэн эмэгтэй хүн; 3. арга бэлгийн бэлгий нь.

ЭМ II өвчнийг засахад ерөндөг болгон хэрэглэх зүйлийн нийт нэр; **эм дом, эм тан** х о р ш.; *эм уух; эм дарууллах;* **эм боловсруулах** (эм үйлдвэрлэх); **эм тугнах** (эм хэмжих); **эмийн үйлдвэр** (эм боловсруулан бэлтгэх газар); **эм барих** х у у ч и р с а н (эмч болох): **эмийн сан** (боловсруулсан эмийг хадгалах, олгох, худалдаалах газар); **эмийн ургамал** (эмд хэрэглэгдэх ургамлын зүйл); **эмийн жор** (эмийг найруулах хувь хэмжээний заавар); **эмийн шошго** (эмийн пайз хаяг); **эм найруулах** (эмийн зүйлийг зааврын ёсоор хувилан нийлүүлэх); **эм найруулагч** (эм найруулах ажил гүйцэтгэгч): эм **судлал** (эмийн зүйл бие махбодод нөлөөлөх чадлыг судлах ухаан); **эм судлалч** (эм судлалд мэрэгжсэн хүн).

ЭМ III хэл зүйд эгшиг болон хүйсийг ялгалахад хэрэглэх үг; **эм эгшиг** (хэлний урдуур өгүүлэгдэх эгшиг); **эм хүйс** (хэл зүйн хүйсийн айн доторхи ялгаврын нэг зүйл; *эртний монгол хэлэнд эр эмийн хүйс байсан байна);* эм үг (а. эм эгшигтэй үгс; б. эм хүйст үгэнд хамаарагдах үгс).

ЭМБЭРЭХ юмны хагарах, нурах; *эмбэрэн унах; уул хад эмбэрэх; шороо чулуу эмбэрэх.*

ЭМГЭГ хүн амьтны биед тогтсон гэм хор; **өвчин эмгэг, эмгэг хуучин** х о р ш.; **эмгэг тусах.**

ЭМГЭГЛҮҮЛЭХ эмгэглэхийн үйлдүүлэх хэв.

ЭМГЭГЛЭХ эмгэг олох, эмгэгтэй болох.

ЭМГЭГРЭХ эмгэг олох, эмгэг суух.

ЭМГЭЛЖ бөөгийн шашны ёсонд: гаднаас гэрт оруулах болсон түүхий идээний цээрийг гаргахад хэрэгтэй гэдэг үүдэнд өлгөсөн дүрс нөхөөс.

ЭМГЭН насжисан эмэгтэй хүн; *эмгэн эх;* эмгэн хумс а м ь т а н (нялцгай биетний анги, дүрс бүрээтэй адил амьтан, толгойдоо туршуул бий бөгөөд хос нүдтэй, төрөл зүйл олон, тэнгэс ба цэнгэг ус хийгээд бас газарт явах нь ч бий, зарим нь цэцэрлэг, ногооны газрыг ч хорлоно); **эмгэн шилбэ** у р г а м а л говь газрын төхөм хонхор сайр суваг ургах нэгэн зүйл модорхог буг, навч нарийн зузаан, хальс цайвар бор).

ЭМГЭНЭЛ эмгэнэх үйлийн нэр; **эмгэнэл гашуудал** х о р ш.; *эмгэнэл хургэх; эмгэнэл илэрхийлэх.*

ЭМГЭНЭЛТЭЙ эмгэнэвэл зохих зүйл бүхий, эмгэнэвэл зохилтой.

ЭМГЭНЭХ өрөвдөх, эгээрэн санагалзах, гашуудах, гомдох сэтгэл төрөх; *садан амрагаас салж хагацан хайрлах эрэх мэтээр эмгэнэх; хайрлалтай зүйлд алдал хохирол тохиолдож нэхэж гомдон эмгэнэх;* **эмгэнэх бичиг** (хүнийг нас нөхцсөн хойно, түүний явсан үйл явдлыг дуртгал болгон нэхэж гомдон бичсэн бичиг).

ЭМГЭЭ 1. эмгэн, эмээ; 2. эмэг.

ЭМДҮНЗ бөднө шувууны эмэгчний нь.

ЭМЖИХ юмны зах сэжүүрт өөр юм барьж мөшгөөрлөн оёх хадах; *дээл эмжих; ширдэг эмжих.*

ЭМЖҮҮЛЭХ эмжихийн үйлдүүлэх хэв.

ЭМЖЭЭР эд юмны зах сэжүүр зэрэгт мөшгөөр хийх эд юм ба мөшгөөр; *эмжээрийн торго; дээлийн эмжээр; эмжээр нь урагджээ.*

ЭМЖЭЭРЛҮҮЛЭХ эмжээрлэхийн үйлдүүлэх хэв.

ЭМЖЭЭРЛЭХ эмжээртэй болгох, эмжих.

ЭМЗЭГ 1. өвчний маш хөндүүрий нь; *эмзэг газар; эмзэг хуруу; эмзэг хүүхэд; эмзэг эрхтэн;* 2. эд бөсийн маш хэврэгий нь; *эмзэг эд бөс; шил бол эмзэг эд;* 3. эрх, танхи; **эрх эмзэг** х о р ш.; *эмзэг хүн; эмзэг зантай амьтан.*

ЭМЗЭГЛҮҮЛЭХ эмзэглэхийн үйлдүүлэх хэв.

ЭМЗЭГЛЭХ 1. өвчний хөндүүр эмзгийг хүлцэж чадахгүй, тэсч ядан аашлах; 2. хэврэг эд юмыг эвдрүүжин гэж ихэд болгоомжлон хүрч ядах; 3. эрх танхи, долгин байдал гаргах; *ширүүхэн хэлсэн үгэнд эмзэглэн уурлах.*

ЭМЛЭХ эмчлэх.

ЭМНҮҮЛЭХ эмнэхийн үйлдүүлэх хэв.

ЭМНЭГ 1. догшин, атар, танхи, ажил эдэлгээнд сурч номхроогүй адгуус мал; **эмнэг хангал, эмнэг догшин** х о р ш.; *эмнэг үрээ; эмнэг сургах; эмнэг малыг эдэлгээнд дасгах;* 2. урьд хагалагдаж тариа тариагүй атар хатуу газар; **эмнэг атар** х о р ш.: *эмнэг газар.*

ЭМНЭГШИХ эмнэг шинжтэй болох, эдэлгээнд сургасан малын дахин эмнэг болох.

ЭМНЭГШҮҮЛЭХ эмнэгшихийн үйлдүүлэх хэв, эмнэгшихэд хүргүүлэх.

ЭМНЭЛЭГ 1. эмнэх, эмчлэх үйлийн нэр; *хүн эмнэлэг; мал эмнэлэг; эмнэлэг хийлгэх; эмнэлэг авах;* 2. эмчлэн сувилах газар, байгууллага; *төв эмнэлэг; нэгдсэн эмнэлэг; хорооны эмнэлэг; аймгийн эмнэлэг; хүүхдийн эмнэлэг; эмнэлгийн газар; эмнэлгийн ажилтан.*

ЭМНЭХ өвчнийг эмчлэн засах; *эмээр эмнэх; аршаанаар эмнэх; хоолоор эмнэх.*

ЭМСГИЙ эмсгэр, үүдэн шүд нь унаж онгойсныг; *эмсгий шүдтэй хүүхэд.*

ЭМСГЭР эмсгий шүдтэй, үүдэн шүд нь онгойж эмсгий болсныг.

ЭМСИЙХ эмсгий болох; *шүд нь эмсийх; уруул нь эмсийх.*

ЭМСЭГ I эмзэг.

ЭМСЭГ II 1. эм зантай; 2. хүүхэмсүү.

ЭМСЭГЛҮҮЛЭХ эмсэглэхийн үйлдүүлэх хэв.

ЭМСЭГЛЭХ 1. хүүхдийг тэврэх, үүрэглэх зэргээр харгалзах; *хүүхэд эмсэглэх;* 2. эмзэглэх.

ЭМТ хүч нэмэгдүүлэх үг; **эмт сэмт** х о р ш.; *эмт цохих; эмт татах; эмт үсрэх.*

ЭМТГИЙ эмтэрхий, сав суулгын амсар өмөрхий сэлтэрхий, эмсгий ч гэнэ.

ЭМТГЭР сав суулга зэргийн юмны ам амсар эмтгий сэмтгий болсны нь; **эмтгэр сэмтгэр** х о р ш.; *эмтгэр аяга.*

ЭМТИЙЛГЭХ эмтийхэд хүргүүлэх.

ЭМТИЙХ эмтгий, эмтгэр болох.

ЭМТЛҮҮЛЭХ эмтлэхийн үйлдүүлэх хэв.

ЭМТЛЭХ эмтэрхий болгох, эмтрэхэд хүргүүлэх.

ЭМТРҮҮ дээл хувцас хийхэд дутсан бяцхан нарийн газарт зүйж оруулах юм, эмтрүүс ч гэнэ; *дээлийн дотор эмтрүү оруулах.*

ЭМТРҮҮДЭХ юманд эмтрүү оруулах; *дээлийн дотор эмтрүүдэх.*

ЭМТРҮҮС эмтрүү.

ЭМТРЭХ 1. эд юмны зах ирмэг зэрэг газрын сэтрэх, эмтгий эмтгэр болох; *аяганы амсар эмтрэх; байшингийн булан эмтрэх;* 2. бусдыг их л өрөвдөн хайрлах; *элэг эмтрэх.*

ЭМТЭН эмтэрхий; **эмтэн сэмтэн** (энд тэндгүй эмтэрхий сэтэрхий болсон нь).

ЭМТЭРХИЙ эд бөсийн эмтэрсний нь; *эмтэрхий шаазан; эмтэрхий түмпэн.*

ЭМХ цэгц журам, аливаа юмны будлиан самуунгүй, замх журамтай байгаа байдлы нь; **эмх замх, эмх замбараа, эмх журам, эмх цэгц** х о р ш.; *эмх замбараагаа алдах; эмх журамтай байх.*

ЭМХГҮЙ журам хураамжгүй, цэгцгүй, самуун задгай юм; *хийсэн юм нь эмхгүй байв.*

ЭМХЛҮҮЛЭХ эмхлэхийн үйлдүүлэх хэв.

ЭМХЛЭХ цэгцтэй, эмхтэй болгох; *хөдөө авч явах юмаа эмхлэх; нүүх гэж гэр зуурын юмаа эмхэлж байв.*

ЭМХРҮҮЛЭХ эмхрэхийн үйлдүүлэх хэв, эмхтэй болгох.

ЭМХРЭХ эмхтэй, цэгцтэй болох; *ажил маань одоогоос л нэг эмхэрч байна.*

ЭМХЭРДҮҮЛЭХ эмхэрдэхийн үйлдүүлэх хэв.

ЭМХЭРДЭХ 1. арьс бөс зэргийн зөөлөн эдээр хийсэн юмны хормой зах, ам амсрыг нугалж моголцогхон болгож оёх; *алчуурын зах эмхэрдэх;* 2. нимгэн төмөрлөгийн зүйлээр үйлдсэн сав эдлэлийн ам захыг матируулан нугалж тогтоох; *яндангийн амсрыг эмхэрдэх.*

ЭМХЭРДЭЭС эмхэрдэж оёсон оёдол.

ЭМХЭТГЭЛ эмхэтгэх үйлийн нэр, эмхэтгэсэн юм; *аман зохиолын эмхэтгэл; хууль дүрмийн эмхэтгэл; шүлгийн эмхэтгэл.*

ЭМХЭТГЭХ 1. эмхлэх, эмхтэй цэгцтэй, журамтай замбараатай болгох; *ажлаа эмхэтгэх;* 2. цуглуулан нэгтгэж нэгэн бөөн болгох; *уран зохиол эмхэтгэх.*

ЭМЦГЭР хүний дээд уруул охор; *эмцгэр уруултай.*

ЭМЦГЭРХЭН арай эмцгэр, нилээд эмцгэр.

ЭМЦЭРХИЙ эмтэрхий.

ЭМЧ өвчнийг анагаах засах мэрэгжлийн хүн; **эмч домч** х о р ш.; *хүний эмч; малын эмч; эмч хүнд энэрэнгүй сэтгэлээс эрхэм зүйлүү* х у у ч; *эмчийн хуучин нь дээр, зурхайчийн шинэ нь дээр* х у у ч; *эмч сайн ч гэсэн өвөртөө тусгүй, хутга хурц ч гэсэн ишиндээ тусгүй*

з ү й р; **бага эмч** (дунд боловсролтой эмч); **их эмч** (дээд боловсролтой эмч).

ЭМЧИЛГЭЭ эмчлэх үйлийн нэр; **эмчилгээ үйлчилгээ** х о р ш.; *эмчилгээ сайтай; эмчилгээ үйлчилгээний ажлыг сайжруулах.*

ЭМЧЛҮҮЛЭГЧ эмчлүүлж байгаа хүн.

ЭМЧЛҮҮЛЭХ 1. эмчлэхийн үйлдүүлэх хэв, эмнүүлэх; 2. эмчлэгдэх.

ЭМЧЛЭГДЭХ эмчлэхийн үйлдэгдэх хэв.

ЭМЧЛЭХ өвчнийг засах анагаах, эмнэх.

ЭМЭГ эцгийн дээд үеийн эмэгтэй хүн; **эмэг эх, эмэг эжий** (өөрийн эцэг эхийн эх).

ЭМЭГЖЭЭЛ эмэгжээр.

ЭМЭГЖЭЭР 1 .эмэгтэй хүний нас залуу боловч хөгшин хүний зан байдалтайгий нь; 2. нас ахимаг эмэгтэй хүн; *манайд нэг эмэгжээр хүн ирэв.*

ЭМЭГТЭЙ эм хүн; *малчин эмэгтэйн сэтгэл; ажилчин эмэгтэй.*

ЭМЭГТЭЙЧҮҮД олон эмэгтэй; *хөдөлмөрчин эмэгтэйчүүд; эмэгтэйчүүдийн баяр; эмэгтэйчүүдийн байгууллага.*

ЭМЭГЧИН зарим амьтны эмий нь; *эмэгчин тахиа.*

ЭМЭЭ насжсан эмэгтэй хүн, эмгээ ч гэдэг.

ЭМЭЭЛ I унах ачих морь малд тохох бүүрэг хавтсаар бүрдсэн хэрэглэлийн нэр, хэлбэр дүр олон янз; **эмээл хазаар** х о р ш.; *орос эмээл; монгол эмээл; эрвээлжин эмээл; эхнэрээсээ ондоо хүн танихгүй, эмээлээсээ өндөр даваа даваагүй* з ү й р; **эмээл тохох** (морь зэрэг уналгын нуруунд эмээл тохруулан тогтоох); **эмээл авах** (морь малд тохсон эмээлийг тайлж авах): **эмээл шуух** (эмээлийг гөлмөөр нь бүтээж оосроор даруулах); **эмээлийн мод** (хоёр бүүрэг хоёр хавтсаар бүрдсэн мод); **эмээлийн бүүрэг** (эмээлийн модны босоо хэлбэртэй хоёр хэсэг, мод); **эмээлийн хавтас** (эмээлийн модны хэвтээ хэлбэртэй хоёр хавтаг мод); **эмээлийн хонго, хонх** (эмээлийн, морины нуруу дагуугийн хөмрөг хөндий газар); **эмээлийн хяр** (эмээлийн бүүрэгний дээд ирмэг дагуугийн тоног); **эмээлийн тоног** (эмээлийн баавар даруулга мэтийн чимэглэл); **эмээлийн ганзага** (эмээлийн өмнө хойт талд юм ганзагалах газар, ганзагалахад хэрэглэх уяа оосор); **эмээлийн угсуурга** (эмээлийн олом жирэм уях гогцоо оосор); **эмээлийн даруулга** (эмээлийн олонцог тогтоох товчин тоног); **эмээлийн баавар** (эмээлийн хавтасны дөрвөн үзүүрийн хавтгийн чимэглэл); **эмээлийн олонцог** (эмээлийн модны суудлын жийрэг бүрээс); **эмээлийн хэрэглэл** (эмээлд хэрэглэгдэх бүх юм); **эмээлийн шуулт** (гөлмийг шуухад хэрэглэх оосор).

ЭМЭЭЛ II эмээх үйлийн нэр, аюул, хэлмэл, зүрхшил, халшрал, жийргэмшил; **аюул эмээл** х о р ш.; *эмээлтэй үйл явдал.*

ЭМЭЭЛ III з у р х а й Улаан нүдэн гаргийн дагуул нэгэн зүйл од.

ЭМЭЭЛГҮЙ I эмээл байхгүй, эмээл тохоогүй.

ЭМЭЭЛГҮЙ II айх эмээх зүйлгүй.

ЭМЭЭЛГЭХ эмээхэд хүрүүлэх.

ЭМЭЭЛЛҮҮЛЭХ эмээллэхийн үйлдүүлэх хэв; *морь эмээллүүлэх.*

ЭМЭЭЛЛЭХ эмээл тохох; *морь эмээллэх; үхэр эмээллэх.*

ЭМЭЭЛЧ (ИН) эмээлийн мод хийдэг хүн.

ЭМЭЭХ айх, аюух, хэлмэх, жийргэмших, халшрах; **айх эмээх** х о р ш.; *настай хүний дэргэд тамхи татахаасаа эмээх юм байна шүү дээ.*

ЭН I 1. эд бөсийн өргөн тийш хэмжээ; *эн өргөнтэй цууямбуу; нарийн энтэй даавуу;* 2. х у у ч и р с а н эд бөсийн хоёр этгээдийн утас битүүгээр нэхсэн зах буюу хуй, хэсэг, **эн зах** х о р ш.; *торго нэг эн шагнав;* **эн сацуу** (хэмжээ адил тэнцүү).

ЭН II хүчин, чинээ; *энтэй бөх; энтэй худалдаачин.*

ЭН III эзлэх талбай, овор, цараа; *эн ихтэй нутаг; эн багатай уул;* **эн захгүй** (хязгааргүй, их; *эн захгүй их нутаг; эн захгүй тоо; эрдэм ухаанд эн зах байхгүй);* ☆ **эн суртал** (зан суртал; ан суртал).

ЭН IV: **эн тэргүүн** анх, хамгийн түрүүч; *эн тэргүүн удаа.*

ЭНГИЙН ерийн, сулын, зүгээр, хувийн, цохолсон онцолсон биш; **энгийн хүн** (албан ажил буюу ямар нэгэн онцгой явдал эрхлээгүй ерийн хүн); **энгийн биш** (ерийн биш, хувийн биш албаны буюу чухал үйл явдал); **энгийн өдөр** (ерийн хэвийн ажилтай буюу сул чөлөөтэй өдөр); **энгийн цаг** (тухайлсан онц ажилгүй сул чөлөөтэй үе); **энгийн явдал** (ерийн үйл ажил); **энгийн хэрэг** (албаны биш,

онц чухал биш, яаралтай биш ерийн хэрэг); **энгийн юм** (аар саар юм, элбэг байдаг юм, албаны биш амин хувийн юм); **энгийн яриа** (ерийн сул яриа); **энгийн худалдаа** (хувийн худалдаа); **энгийн хувцас** (гоёлын биш, ёслолын буюу албаны биш хувцас); **энгийн залуучууд** (залуучуудын эвлэлийн гишүүн бус залуучууд).

ЭНГҮЙ хэмжээ маш их; *энгүй баян сүрэг; энгүй эрдэмтэй хүн; энгүй олон амьтан.*

ЭНГҮҮН энгийн, ерийн.

ЭНГЭДЭХ энгэрээ ярах, дээлийн энгэрийг онгойлгож өвчүүгээ гаргах.

ЭНГЭР 1. дээл хувцасны өмнөх этгээд; **энгэр хормой, энгэр заам** х о р ш.: *гадаад энгэр; дотоод энгэр;* **энгэрийн хараа** (дээлийн гадаад энгэрийн дээд үзүүрийн товч хадах дүгрэглэсэн газар); **энгэрийн товч** (дээл хувцасны энгэрийн хараад хадсан товч); **энгэрийн шилбэ** (дээл хувцасны энгэрийн товч торгох гогцоо); **энгэрийн зүүлт** (эмэгтэйчүүдийн энгэртээ зүүх элдэв чимэг); **энгэрийн цаг** (энгэрт зүүж явдаг оосортой цаг); 2. уул хярын өвөр этгээд; *энгэр руу; энгэр өөд; энгэр газар ээвэр дулаан.*

ЭНГЭРЛҮҮЛЭХ энгэрлэхийн үйлдүүлэх хэв; *хонио энгэрлүүлэх.*

ЭНГЭРЛЭХ уулын энгэрээр явах зорчих: *хонь энгэрлэн билчих.*

ЭНГЭСЭГ эмэгтэйчүүд хацар уруулдаа түрхэх улаан будаг; **оо энгэсэг** х о р ш.; *энгэсэг түрхэх.*

ЭНГЭСЭГДҮҮЛЭХ энгэсэгдэхийн үйлдүүлэх хэв.

ЭНГЭСЭГДЭХ гоёмсоглож, нүүр хацартаа энгэсэг түрхэх.

ЭНД тэнд биш, энэ газарт байгаа юмыг зааж хэлэлцэхэд хэрэглэх үг; *би өчигдөр энд ирэв; энд тийм хүн байхгүй; чи энд зогс; энд 5 хүртэл бай; энд байшин байсан газар; би энд байхгүй;* **энд тэнд** (ховор цөөн; *энд тэнд нэг хоёр хүн; энд тэнд нэг хоёр мод;* **энд тэндгүй** (а. элбэг, үлэмж, хааягүй; *энд тэндгүй айл бий; энд тэндгүй ус байна;* б. үлэмжхэн сарниж тарсны нь; *манай адуу энд тэндгүй тарав; миний багаж хэрэгсэл энд тэндгүй сарнижээ).*

ЭНДҮҮ эндүүрч солиу буруу болгосны нь: **андуу эндүү, эндүү ташаа** х о р ш.; *эндүү яирх; эндүү бодох; та жаахан эндүү ярьж байна.*

ЭНДҮҮЛЭХ эндэхийн үйлдүүлэх хэв.

ЭНДҮҮРҮҮЛЭХ эндүүрэхийн үйлдүүлэх хэв, эндүүрэхэд хүргүүлэх.

ЭНДҮҮРЭЛ эндүүрэх үйлийн нэр, эндүүрсэн ташаарсны нь, андуурал; **эндүүрэл андуурал** х о р ш..

ЭНДҮҮРЭХ үг бодлого, үйл явдлын зэргэт самуурах ташаарах зэргээр солиу буруу болгох; **андуурах эндүүрэх, эндүүрэх ташаарах** х о р ш.; *эндүүрч ярих; эндүүрч таних; эндүүрч дуудах;* **эндүүрэм** (эндүүрч болмоор, андуурам, эндүүрмээр ч гэдэг; *эндүүрэм адилхан хүүхэд байна).*

ЭНДЭГДЭЛ эндэгдэх үйлийн нэр, ташаарал, осол алдаа; **осол эндэгдэл, алдагдал эндэгдэл** х о р ш.: *эндэгдэл гаргах.*

ЭНДЭГДЭХ эндэхийн үйлдэгдэх хэв, осолдох ташаарах.

ЭНДЭЛ алдал, осол, гэнэдэл; **алдал эндэл, осол эндэл** х о р ш.; *ажил дээр осол эндэл гаргаж болохгүй.*

ЭНДЭХ I 1. үйл ажилд гэнэдэх, ташаарах, осолдох; **алдах эндэх, эндэх ташаарах, эндэх гэнэдэх** х о р ш.; 2. хүний үхэхийг зайлуулан хэлэх үг; *нэг хүн эндэж гэнэ;* **эндэх буюу** (хэрхэвч эндэхгүй).

ЭНДЭХ II 1. энэ газрынх, энэ газар дахь; *эндэхийн хүн; эндэхийн эд;* 2. хүнийг хүндэтгэж хэлэхэд хэрэглэнэ; *эндэхийн бодол ямар байгааг сонсохыг хүснэ.*

ЭНДЭХГҮЙ осолдохгүй, андахгүй, ташаарахгүй; *та эндэхгүй хашир хүн байгаа юм.*

ЭНЕРГИ материйн үндсэн чанаруудын нэг бөгөөд түүний хөдөлгөөний хэмжээ, ажил бүтээх чадвар, эрчим, хүчин; **механик энерги** (механик хөдөлгөөний эрчим хүчин); **дулааны энерги** (атом, молекул электрон зэрэг хэсгүүдийн замбараагүй хөдөлгөөнөөс үүсэх эрчим хүчин); **цахилгаан энерги** (цахилгаан цэнэгүүдийн харилцан үйлчлэл, хөдөлгөөнөөс үүсэх эрчим хүчин); **атомын энерги** (протон нейтрон зэрэг цөмийн хэсгүүдийн харилцан үйлчлэлээс үүсэх эрчим хүчин).

ЭННЭХ эгнэх.

ЭННЭХГҮЙ эгнэхгүй.

ЭННЭЭ (Н) эгнээ (н).

ЭНСЛЭХ 1. донслох; **энслэх донслох** х о р ш.; 2. энэлэх зовних, шаналах; **энслэх шаналах** х о р ш..

ЭНСЭН: энсэн хонсон уйлах тэсч ядан уйлах.

ЭНСЭХ ямар нэгэн хүссэн ээрсэн юмыг ихэд мөрөөдөж хүслэн болох.

ЭНТЭЙ эн бүхий, эн ихтэй, эн сайтай; **энтэй уул** (том уул); **энтэй нуур** (томоохон нуур); **энтэй дурдам** (бүхэл дурдам); **энтэй хүн** (их чадалтай хүн); **энтэй айл** (баян чинээлэг айл); **энтэй морь** (явдал чадал сайтай морь); **энтэй наадам** (хөл хөгжөөн ихтэй сайхан наадам).

ЭНТЭЭ энэ газарт байгаагий нь; *уулын энтээ; Туул голын энтээ.*

ЭНТЭЭШЭЭ одоогоос хойш байн байсаар гэсэн санаа; *энтээшээ болох биз ээ; энтээшээ сайжрах болов уу.*

ЭНҮҮНИЙ үүнд харьяалагдахыг заах төлөөний үг; *энүүний юм; энүүний ном.*

ЭНҮҮНИЙХ үүнд хамаатай болохыг заасан төлөөний үг; *тэр ном чинь энүүнийх.*

ЭНҮҮХЭН 1. энд маш ойрхон; *энүүхэн харагдаж байна; энүүхэнд явж байна;* 2. чамлахад хэрэглэх аялга; *энүүхэн үү дээ; энүүхнээр чинь юу хийдэг юм бэ?*

ЭНХ нийтээр амар амгалан түвшин байхыг нь; **энх түвшин, энх амгалан, энх тайван, энх амар** х о р ш.; **энх мэнд** (энх тунх); **энх эрүүл** (хүн амьтны биед тохиолдсон өвчин эмгэггүйгий нь); **энх тунх** (хүний эрүүл саруул байсан үеийг хожим дурдан хэлэлцэхэд хэрэглэх үг); **энх тайван** (дайн самуун, маргаан тэмцэлгүй, хотлоор тайван байхыг; *энх тайвны төлөө тэмцэл; Дэлхий дахины Энх тайвны зөвлөл; энх тайван цаг).*

ЭНХЖИН үүрд амгалан тайван, түвшин; **энхжингийн орон** (шашны ёсонд: сайн үйлийн үрээр заяагдаж төрөх жаргалангийн орон, диваажин ч гэдэг).

ЭНХЖИХ энх болох, амар түвшин болох, тайван сайхан болох; *Алтай Хангай хоёрын завсарт атар баялаг орон, аав эжийн минь оршсон ашдын заяасан нутаг, алтан нарны туяанд энхжин тогтсон орон, мөнгөн сарны гэрэлд мөнхжин гялалзсан орон* (Д. Нацагдорж «Миний нутаг»).

ЭНХЖҮҮЛЭХ энхжихийн үйлдүүлэх хэв, энх болгох.

ЭНХЛЭГ: энхлэг мод у р г а м а л гурван метр орчим өндөр, навч нь хуайс модны адил, иш нь улаан, өргөстэй, навч нь зулгардаггүй, дөрвөн цагт хувирдаггүй нэгэн зүйл мод; **энхлэг цэцэг** у р г а м а л (өндөр нь нэг хос алд, намар хэд хэдэн арван цэцэг багларан цэцэглэнэ, дөрвөн хэлтэстэй, тугар цэцэгтэй адил, улаан цагаан өнгөтэй, үүл адил үзэгдэг нэгэн зүйл цэцэг).

ЭНХРИЙ бусдаас илүү үлэмжхэн хайрлагдах юм; **эрх энхрий** х о р ш.; *энхрий хүүхэд; энхрий хайрт; энхрий хайрт нам засаг.*

ЭНХРИЙЛҮҮЛЭХ 1. энхрийлэхийн үйлдүүлэх хэв; 2. энхрийлэгдэх.

ЭНХРИЙЛЭХ тансаглах, хайрлах; *бага хүүхдийг тансаглан энхрийлэх; мал юмыг хайрлан энхрийлэх.*

ЭНХРЭГ энхрий; **энхрэг үг** (хайрлан дотнолж сургасан үг).

ЭНХРЭГЛЭХ энхрийлэх, хайрлах.

ЭНХРЭХ 1. энхрийлэх; 2. удтал уулзаагүй догно хүнтэйгээ уулзаж харилцан тэврэлдэж элэгсэглэх.

ЭНХТ: энхт бялзуухай а м ь т а н богшрогын нам, толгойдоо өвөгтэй, гох мэт хушуутай, бие нь цагаавтар, сүүл нь хар болоод үзүүр нь улбар өнгөтэй нэгэн зүйл шувуу.

ЭНХЭЛ: энхэл тунхал гүдгэр хотгор бөгөөд явахад түвшин биш газар.

ЭНХЭР энхрий.

ЭНЭ ойрын юмыг бусдын зүг заах төлөөний үг; *энэ жил; энэ өдөр; энэ хэрэг; энэ хүн; энэ өглөө; энэ тушаа;* **энэ тэр** (олон юмны нэрийг нэрлэж, бусдыг хамтатган өгүүлэхэд хэрэглэх үг; *Бат энэ тэрийг дууд; хөсөг хүнс энэ тэр юм өг; энэ тэр юмаар битгий хөөцөлд);* **энэ тушаа** (энд, энэ орчим, энэ хавь); **энэ дээр** (а. үүнд буюу үүний дээр; *энэ дээр суу; энэ дээр тавь;* б. энэ дотор, энэ газар; *чиний аав энэ хурал дээр ирэх үү? чи энэ дээр хэзээ ирэв?* в. энэ байдал гэх санаа; *энэ дээрээс бодвол; энэ дээрээс үзвэл;* г. үүн, эндээс; *энэ дээрээс унш; энэ дээрээс оё);* **энэ мэт** (энэ, үүнтэй адил, ойрын юм буюу түүнтэй адилшаах юмыг дурдахад хэрэглэх үг; *энэ мэтийн хүн; энэ мэтийн үг явдал);* **энэ үү** (юмыг магадлан лавлахад хэрэглэх үг; *тэр ном чинь энэ үү? хүрээлэн гэдэг чинь энэ үү?).*

ЭНЭГШИЛ энэгших үйлийн нэр.

ЭНЭГШИХ харилцан дасалцаж ижилдэх.

ЭНЭГШҮҮЛЭХ энэгшихийн үйлдүүлэх хэв.

ЭНЭЛГЭХ энэлэхэд хүрүүлэх, энэлүүлэх, эмгэнүүлэх, зовниулах, шаналгах.

ЭНЭЛҮҮЛЭХ энэлэхийн үйлдүүлэх хэв, энэлгэх, зовоох.

ЭНЭЛЭГ гашуу, уярал.

ЭНЭЛЭГТЭЙ санаа сэтгэл эмгэнэл зовнилтой, гашуудал уяралтай.

ЭНЭЛЭЛ энэлэх үйлийн нэр, шаналал, зовнил, гашуудал; **энэлэл шаналал, энэлэл зовнил** х о р ш..

ЭНЭЛЭЛТ энэлэлтэй.

ЭНЭЛЭЛТЭЙ энэлэл бүхий, зовнилтой, гашуудалтай, уяралтай.

ЭНЭЛЭХ санаа сэтгэл эмгэнэх, зовох, шаналах; **энэлэх зовох, энэлэх шаналах** х о р ш..

ЭНЭРҮҮЛЭХ 1. энэрэхийн үйлдүүлэх хэв; 2. энэрэгдэх.

ЭНЭРЭЛ энэрэх үйлийн нэр, энэрэх сэтгэлий нь; **хайр энэрэл** х о р ш.; *гэгээн төрийн хайр энэрлээр.*

ЭНЭРЭЛГҮЙ энэрэх өрөвдөх сэтгэлгүй, хатан хатуу сэтгэлтэй.

ЭНЭРЭЛТ энэрэлтэй.

ЭНЭРЭЛТЭЙ энэрэл бүхий, энэрэх сэтгэлтэй.

ЭНЭРЭНГҮЙ энэрэх, өршөөх, өрөвч сэтгэлтэй; *энэрэнгүй сэтгэлээр өршөөл үзүүлэх;* **энэрэнгүй хэрээ** (хон хэрээ).

ЭНЭРЭХ өршөөх, хайрлах, өрөвдөх; **энэрэх хайрлах, энэрэх өршөөх** х о р ш.; *хайрлан энэрэх; энэрэх сэтгэлгүй.*

ЭНЭРЭХҮЙ өршөөн хайрлах сайн санаа.

ЭНЭСХ шувууны өдний имсгэл.

ЭНСЭГ энэх.

ЭНЭТХЭГ: энэтхэг давс аммониомын давс, эмнэлэгт хэрэглэнэ, хятад давс, жамц давс ч гэдэг.

ЭНЭТЭЭ юмны наад этгээд талд бий; *голын энэтээ; гэрийн энэтээ.*

ЭНЭХ үүд хаалганы хавтасны дээд хөндлөнгий нь, энэсх, тотго ч гэдэг; *хаалганы энэх.*

ЭНЭХҮҮ энэ, сая дурдсан буюу үзсэн сонссон, эсвэл нүдний өмнө байгаа эл юмыг заан хэлэлцэхэд хэрэглэх үг.

ЭНЭХЭН зуур, юмыг бяцхан бага гэж чамлахад хэрэглэх үг; *энэхэн төдий юм; энэхэн хооронд; энэхэн зуур; энэхэн завсар;* **энэхэн тэрхэн** (бага сага, энэ тэр; *асуусны хариуг энэхэн тэрхэн гэж өнгөрүүлэв; энэхэн тэрхэн гэж шалтгаалав.*

ЭНЭЭХЭН энэхэн.

ЭР I 1. эм гэдгийн эсрэг утга, эмийн бус бэлэг бүхийг; *эр хүн; эр хонь; эр хүн зорьсондоо, эр морь харайсандаа* з ү й р; *эрийг бүү бас, далайг бүү янд* з ү й р; *эрийг нас дардаг, уулыг цас дардаг* х у у ч; **эрийн бэлэг** (эр амьтны бэлэг эрхтэн); **эр адаг** (эр нохой өтөг); **эрийн гурван наадам** (Монголчуудын бөх барилдах, морь уралдах, сур харвах гурван зүйл наадам): 2. насанд хүрсэн эрэгтэйчүүд; *эр болжээ тэр чинь;* **эр болох** (а. эр хүний адил чадамгайгаар хөдлөх аашлах; б. бага хүүхдийн өсч том болох); **эрийн цээ** (хуулийн бүрэн эрх эдлэх нас); **эрийн цээнд хүрэх** (хуулийн бүрэн эрх эдлэх насанд хүрэх); 3. эхнэр авсан эрэгтэй хүн; *миний эр нөхөр;* **эр эм** (хос холбоо); **эр эм болох** (хос холбоо болох, гэр бүл болох); 4. чадал тэнхээ; **эр чадал** х о р ш.: **эртэй** (а. хүн амьтны эрэлхэг чадамгай; б. мод зэргийн юмны хатуу чийрэг); **эргүй** (чадал тэнхээ ядуу буурай); **эр гаргах** (үйл ажилд чадал чинээгээр хүчлэх); **эр сайтай** (төрөлхийн чадал тэнхээтэй); **эр муутай** (төрөлхийн чадал муутай); **сайн эр** (зориг самбаа ихтэй эр); **муу эр** (зориг самбаа муутай эр); **эр шууд** (зан авир чигч шудрага буюу хүн амьтны эрэмгий чадамгайгий нь); **эрийн ханштай** (а. эрэгтэй хүмүүсийн бусдын үйл ажилд үнэнч шудрагаар тэтгэн туслах зантайгий нь; б. нөхөр сайтай, нөхөртөө тусламтгай, нөхрийн ханштай); 5. арга билгийн аргы нь; **эр байт** (эрвэй, нэг алд); **эрийн нэг** (юмны авд нийлүүлж хураамжилж болохгүй тарсан цуцарсны нь; *эрийн нэг болгох);* **эр дэгээ** (барилдахад эсэргүүцлийн салтааны дотроос гадаа тийш, хөлөөр гохдон хийх нэгэн зүйлийн мэх); **эр хар алхам** (морины сайвар явдал биш бөгөөд тэлүүлэн түрэлхийлж, хурдавчлан алхлах явдал): **эр бар** (алив юмыг дийлэх давах хүч чадалтай); **эр цагаан** а м ь т а н (янз байдал морьтой төстэй, ганц эвэртэй, үхэр шиг сүүлтэй нэгэн зүйл гөрөөс)

ЭР II эгшиг болон хүйсийг ялгахад хэрэглэх үг; **эр эгшиг** (хэлний хойгуур өгүүлэгдэх эгшиг); **эр хүйс** (хэл зүйн хүйсийн айн доторхи ялгаврын нэг зүйл); **эр үг** (а. эр эгшигт үгс; б. эр хүйст үгэнд хамаарагдах үгс).

ЭРВИЙХ эрвэн сэрвэн үзэгдэх, сэрвийх; **эрвийх сэрвийх** х о р ш.; **эрвийх тэрвийх, эрвийх сэрвийх** (үйл ажилд чадахуйц олноороо хүчин хавсрах; *хот тохижуулах ажилд эрвийх гэрвийхээрээ оролцов).*

ЭРВЭГ: эрвэг сэрвэг эрвэн сэрвэн.

ЭРВЭГНЭХ сэрвэгнэх; **эрвэгнэх сэрвэгнэх** х о р ш.. ᠡᠷᠪᠡᠭᠨᠡᠬᠦ

ЭРВЭГЧ бяцхан эрвээхэй. ᠡᠷᠪᠡᠭᠴᠢ

ЭРВЭЙ нэг алд, хуучин толь бичигт найман тохойг нэг эрвэй гэсэн байдаг. ᠡᠷᠪᠡᠢ

ЭРВЭЙЛҮҮЛЭХ эрвэйлэхийн үйлдүүлэх хэв. ᠡᠷᠪᠡᠢᠯᠡᠭᠦᠯᠬᠦ

ЭРВЭЙЛЭХ алдлах. ᠡᠷᠪᠡᠢᠯᠡᠬᠦ

ЭРВЭЛЗҮҮЛЭХ эрвэлзэхийн үйлдүүлэх хэв. ᠡᠷᠪᠡᠯᠵᠦᠭᠦᠯᠬᠦ

ЭРВЭЛЗЭХ үйл ажилд цовоо сэргэлэн, хөнгөн гавшгай хөдлөх; **эрвэлзэх сэрвэлзэх** х о р ш.; *унахад эрвэлзсэн сайн морь; ажил хөдөлмөрт эрвэлзсэн залуу шүү;* **эрвэлзэх сэрвэлзэх** (эрэвгэр сэрэвгэр юмны бараг бүрэг үзэгдэх хөдлөх). ᠡᠷᠪᠡᠯᠵᠦᠬᠦ

ЭРВЭН: эрвэн сэрвэн 1. мод хад зэргийн эрэвгэр сэрэвгэр юмны энд тэнд сэрвийлцэж байгаагий нь; 2. олон хөлт амьтны хөдлөх байдал. ᠡᠷᠪᠡᠨ

ЭРВЭСХИЙХ морь малын нүд гэнт хөдлөн харах сэрвэлзэх. ᠡᠷᠪᠡᠰᠬᠢᠶᠡᠬᠦ

ЭРВЭЭЛЖ 1. эмээлийн хүндэтгэл; 2. хүүхдийн эмээл, жижиг эмээл. ᠡᠷᠪᠡᠭᠯᠡᠵᠦ • ᠡᠷᠪᠡᠭᠯᠡᠵᠦ

ЭРВЭЭЛЖЛЭХ эмээллэх; *морь эрвээлжлэх.* ᠡᠷᠪᠡᠭᠯᠡᠵᠯᠡᠬᠦ • ᠡᠷᠪᠡᠭᠯᠡᠵᠯᠡᠬᠦ

ЭРВЭЭХИЙ I а м ь т а н дэлхийд түгээмэл орших нэг төрлийн шавьж, зүйл ялгал маш олон хос хоёр далавчтай, далавчны өнгө янз бүр, цэцгийн шимийг идэж амьдрана; **эрвээхийт цэцэг** у р г а м а л (бут бутаар ургадаг, цагаан цэцэгтэй, нэг хүйстэй, хаврын сүүлчээр цэцэглэдэг, хэлтэс нь эрвээхийн жигүүртэй адил нэгэн зүйл цэцэг). ᠡᠷᠪᠡᠭᠴᠢ

ЭРВЭЭХИЙ II өмхий хатиг гэдэг нэгэн зүйл яр өвчин; эрвээхий яр.

ЭРГҮЙ чадалгүй. ᠡᠷᠭᠦᠢ ᠴᠢᠳᠠᠯᠭᠦᠢ

ЭРГҮҮ I ухаан мохдог, мунхаг; **эргүү тэнэг, эргүү мунхаг** х о р ш.. ᠡᠷᠭᠦᠦ

ЭРГҮҮ II хонь үхэр зэрэг зарим малд тохиолдох өвчин; *эргүү хурга; эргүү бяруу.* ᠡᠷᠭᠦᠦ • ᠡᠷᠭᠦᠦ

ЭРГҮҮДЭХ хэтэрхий эргүү болох. ᠡᠷᠭᠦᠦᠳᠬᠦ

ЭРГҮҮЛ I юмны гадаад бие ба нүх хөндийг засах гаргах мэтэд эргүүлэн хэрэглэх багаж. ᠡᠷᠭᠦᠭᠦᠯ

ЭРГҮҮЛ II хянах сэргийлэх буюу харж харгалзахын тул эргэж явах албан тушаалтан; *эргүүлд гарах; хотын эргүүл; гудамжны эргүүл.* ᠡᠷᠭᠦᠭᠦᠯ

ЭРГҮҮЛ III: **эргүүл цэцэг** у р г а м а л цэцгийн өнгө хүрэн, сийрэг навчтай, хурц сүрхий үнэртэй нэг зүйл цэцэг.

ЭРГҮҮЛ IV тогоо шанага зэрэг гал тогооны аар саар хэрэглэгдэхүүн юмыг тавих эргэнэг тавиур, зарим газар эргүүлэгч гэдэг.

ЭРГҮҮЛДҮҮЛЭХ эргүүлдэхийн үйлдүүлэх хэв. ᠡᠷᠭᠦᠭᠦᠯᠳᠦᠭᠦᠯᠬᠦ • ᠡᠷᠭᠦᠭᠦᠯᠳᠦᠭᠦᠯᠬᠦ

ЭРГҮҮЛДЭХ I 1. эргүүл багажаар юм хумыг үйлдэх засах; 2. эргүүлэгт хадаас мэтийг мушгиж эргүүлэх. ᠡᠷᠭᠦᠭᠦᠯᠳᠦᠬᠦ

ЭРГҮҮЛДЭХ II хүн амьтны хүссэн горилсон юмаа шаардан шавдаж авсаар болихгүй шалах. ᠡᠷᠭᠦᠭᠦᠯᠳᠦᠬᠦ

ЭРГҮҮЛДЭХ III юмыг байн байн эргүүлэх.

ЭРГҮҮЛЛҮҮЛЭХ эргүүлэхийн үйлдүүлэх хэв. ᠡᠷᠭᠦᠭᠦᠯᠭᠦᠭᠦᠯᠬᠦ

ЭРГҮҮЛЭГ I эргэдэг, эргүүлдэг юм, эргэсэн юмсын нийт нэр, 1. эрэг ба шургийн мушгимал суваг; *бууны гол төмрийн эргүүлэг зураас;* 2. ус мөрний ойл; *усны эргүүлэг; эргүүлэгтэй газар усанд орж болохгүй;* 3. амьтны үсний ширхэг эргэн ургасан нь; *үсний эргүүлэг;* 4. мал тэжээврийн уяа оосор, ороолдох эрчлэхийг хамгаалж мушгивал эргэж байхаар хийсэн хэрэглэл; *аргамжааны эргүүлэг;* 5. худгийн усны утгуурын оосор мэтийг ороон татаж гаргах ба дээс утас мэтийг ороох хэрэглэл; *худгийн эргүүлэг оосор.* ᠡᠷᠭᠦᠭᠦᠯᠭᠡᠭ

ЭРГҮҮЛЭГ II эргэнэг тавиур.

ЭРГҮҮЛЭХ эргэхийн үйлдүүлэх хэв; *номын хуудас эргүүлэх;* 1. буцаах, эгүүлэн илгээх; *өөр хүний захидал ирсэн тул эргүүлэн буцаав; билчсэн хонь эргүүлээд ирэв;* 2. урвуулах; *хуучирсан дээлийн өнгийг эргүүлэн дахин өнгө татах; хүүдий эргүүлэх;* 3. эргүүл явуулан хянах шалгах; *тусгай хүн явуулж манаад эргүүлэх;* ☆ **өвчин эргүүлэх** (өвчин байн байн тусах. ᠡᠷᠭᠦᠭᠦᠯᠬᠦ

ЭРГҮҮТҮҮЛЭХ эргүүтэхийн үйлдүүлэх хэв, эргүүтэхэд хүргүүлэх. ᠡᠷᠭᠦᠭᠦᠳᠭᠦᠭᠦᠯᠬᠦ

ЭРГҮҮТЭХ I хүн амьтны ухаан бодлого төөрөгдөн балардах. ᠡᠷᠭᠦᠭᠦᠳᠭᠦᠬᠦ

ЭРГҮҮТЭХ II малд эргүү өвчин тохиолдох.

ЭРГЭЛ 1. юмны эргэхий нь; 2. мөргөл; **эргэл мөргөл** х о р ш.. ᠡᠷᠭᠡᠯ

ЭРГЭЛДҮҮЛЭХ эргэлдэхийн үйлдүүлэх хэв. ᠡᠷᠭᠡᠯᠳᠦᠭᠦᠯᠬᠦ

ЭРГЭЛДЭХ эргэхийн үйлдэлдэх хэв, байн байн эргэх; *бужиглэн эргэлдэж байв; үерийн ус хүчтэй эрэлдэн ирэв.* ᠡᠷᠭᠡᠯᠳᠦᠬᠦ

ЭРГЭЛЗҮҮЛЭХ эргэлзэхийн үйлдүүлэх хэв. ᠡᠷᠭᠡᠯᠵᠦᠭᠦᠯᠬᠦ

ЭРГЭЛЗЭЛ эргэлзэх үйлийн нэр, татгалзал, болгоомжлол.

ЭРГЭЛЗЭХ I үйл ажилд болгоомжлон тээнэгэлзэх; *арай тийм биш боловуу гэж эргэлзэн бодсоор байв.*

ЭРГЭЛЗЭХ II юмыг хүсч эрэн санагалзах, эрмэлзэх.

ЭРГЭЛЗЭЭ эргэлзэх үйлийн нэр, эргэлзэх татгалзах, эргэлзэл.

ЭРГЭЛТ орчих тойрох, урвах хөлбөрөх, буцах өөрчлөхий нь; *хүрдний эргэлт; усны эргэлт; үсний эргэлт; чиглэсэн зорьсныг өөрчлөх эргэлт;* **цагийн эргэлт** (цагийн улиран хувьсах өөрчлөлт; *дөрвөн цагийн эргэлт*); **эргэлт оруулах** (эмнэлэгт байгаа буюу түр хориотой байгаа хүнд хүнс ба эд хувцасны зүйлийг дамжуулан өгөх буюу уулзах уулзалт).

ЭРГЭЛТГҮЙ буцалтгүй, өөрчлөлтгүй, урвалт хөрвөлтгүй; *эргэлтгүй тусламж үзүүлэх.*

ЭРГЭЛЭГ эргэх үйлийн нэр, юмны эргэхий нь

ЭРГЭМШИХ эрэмших, даврах, хэтрэх.

ЭРГЭН: эргэн тойрон 1. юмны зах хязгаараар буюу гадуур нь тойрон байгаа юм; 2. орчин, орчин тойрон; *эргэн тойрны юмыг ажиглан үзэх.*

ЭРГЭНЭГ тогоо шанага, аяга таваг зэргийг агуулах, сав хэрэглэлийг тавихад тохируулж хийсэн зүйл, хэлбэр байдал янз янз, зарим газар эргүүл ч гэдэг.

ЭРГЭХ 1. орчих, тойрох, хөдөлгөөн хийх; **эргэх тойрох** х о р ш.; *машины дугуй эргэх; манай дэлхий тэнхлэгээ тойрон эргэнэ; гэрээ эргэх;* 2. буцах, эгэх; *сургууль төгсөөд гурван жилийн дараа гэртээ эргэж ирэв; эргэж ирэхэд ээж сайхан, эргүүлж мөлжихөд хүзүү сайхан* х у у ч; 3. хянах сэргийлэх зорилгоор шалган үзэх; **эргэх шалгах** х о р ш.; *харуул манаа эргэх; тариа хураалтын явцыг эргэж шалгасаар байв;* 4. эмнэлэгт байгаа буюу түр хориотой байгаа хүнд хүнс, эд хувцасны зүйлийг дамжуулан өгөх буюу биеэр уулзах, эргэлт оруулах; *өвчтэй хүнийг эргэх; эмнэлэгт байгаа дүүгээ эргэх;* 5. ш и л ж с э н урвах, буцах; **эргэх буцах** х о р ш.; *санаа эргэх; чи битгий эргэж буцаад бай! нэг л шийдсэнээрээ бол;* 6. ш и л ж с э н ухаан бодлого самуурах, дүйрэх; **тархи эргэх, толгой эргэх** (а. ямар нэгэн шалтгаанаас дотор муухай болж, тэнцвэрээ алдах; *толгой эргэж дотор муухай болох;* б. самуурч учраа олохгүй болох; *олон данс бүртгэлд толгой минь эргэв;* в. зүг чиг баримжаагаа алдах; *их шуурганаар толгой эргэж хаа явж байгаагаа мэдэхгүй болов*); ☆ **чоно эргэх** (хот хашаанд бий малыг идэхээр чоно сэм ирэх).

ЭРГЭЦҮҮЛЭХ эргэцэхийн үйлдүүлэх хэв, юмыг байн байн хянаж бодох, үзэх; *эргэцүүлэн бодох; эргэцүүлэн хянах.*

ЭРГЭЦЭГ мөрөн гол, уул зав, ам зэрэг хотгор газарт тулгарч эгц болсон хажуу явцуу газар; **эргэцэг мөргөцөг** х о р ш..

ЭРГЭЦЭХ 1. юмыг нягтлан хянаж бодох; *эргэцэн бодох;* 2. байн байн эргэх, эргэлдэх; 3. хоргодох: **эргэцэх хоргодох** х о р ш..

ЭРГЭЦЭЭХ 1. эргэцэхэд хүрүүлэх, эргэцүүлэх; 2. эргэцэх; 3. хоргоох; **эргэцээх хоргоох** х о р ш..

ЭРДҮҮ I чийрэг чадамгай; *эрдүү хүн.*

ЭРДҮҮ II намаг шаваргүй, атар сэргэлэн газар; *эрдүү газар.*

ЭРДҮНЭ бөдөө шувууны эрэгчин.

ЭРДЛЭХ эрслэх, шулуудах, шийдэх.

ЭРДЭМ 1. сургуулиар сурч боловсорсон, дадлага хичээлээр мэрэгжин сурсан мэдлэгийн цогц; **эрдэм боловсрол, эрдэм мэрэгжил, эрдэм мэдлэг** х о р ш.; *эрдэм шинжилгээний ажил; эрдэм шинжилгээний ажилтан; эрдэм сурах; эрдмийн зэрэг хамгаалах; эрдмийг хичээлээр сурдаг, эрлийг сурлаар олдог* х у у ч; *эрдмийг гүн гэж бүү цөхөр, эндэгдлийг бага гэж бүү омгойл* х у у ч; **ерөнхий эрдэм** (байгаль, нийгмийн үзэгдлийг тайлбарлах хийгээд мэрэгжил эзэмшихэд чухал хэрэгцээ бүхий шинжлэх ухааны ерөнхий үндэс); **эрдмийн зөвлөл** (дээд сургуулиуд болон зарим эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд байгуулсан зөвлөл, энэ зөвлөл нь эрдэм шинжилгээний ажлын төлөвлөгөө, эрдэм шинжилгээний ажилтан нарын ажлын үр дүн, эрдмийн зэрэг олгох мэтийн асуудлыг хэлэлцэнэ); 2. зарим юмны ид, чадал: **ид эрдэм, чадал эрдэм** х о р ш.; *зэвэрч өнгө нь гутдаггүй нь алтны эрдэм; хурдан морины эрдэм.*

ЭРДЭМТ эрдэмтэй.

ЭРДЭМТЭЙ эрдэм бүхий; *эрдэмтэй хүн; эрдэмтэй эм; эрдэмтэй морь; эрдэмтэй хүн эрэлгүй.*

ЭРДЭМТЭН 1. шинжлэх ухааны ямар нэгэн салбарт онцгой мэрэгжсэн хүн; **эрдэмтэн мэргэд** х о р ш.; 2. эрдмийн зэрэгтэй; *дэд эрдэмтэн.*

ЭРДЭНЭ маш ховор чухаг, их үнэтэй юмс; **эрдэм эрдэнэ, чандмань эрдэнэ** (маш чухаг, олдошгүй юм); **эрдэнийн чулуу** (ховор бөгөөд үнэ бүхий сайн чанарын чулуулаг); **эрдэнийн сан** (маш ховор эрдэнийн зүйлсийг цогцолсон газар); **есөн эрдэнэ** (алт, мөнгө, төмөр, зэс, дүн, оюу, номин, шүр, сувд); ☆ **эрдэнэ шиш** у р г а м а л (нэг наст тарна, том навчтай, өндөр ургадаг, боргоцойд хуралдан ургадаг шар өнгийн үр бүхий ургамал, үрийг болговсруулж хүн идэхээс гадна малд сайн тэжээл болно).

ЭРДЭНЭЛИГ: эрдэнэлиг цэцэг у р г а м а л салаа навч жирхрүү цэцэгтэй адилавтар, навч нь нягт, цэцэг нь няг, улбалзаж гялбалзан гэрэлтсэн сайхан өнгөтэй нэгэн зүйл цэцэг.

ЭРДЭНЭТ эрдэнэтэй.

ЭРДЭНЭТЭЙ эрдэнэ бүхий юм.

ЭРДЭС газрын гадрагад бий ашигт малтмалын зүйл; **эрдсийн зүй, эрдсийн судлал** (эрдсийн *физик-химийн чанар, төрөл* зүйл хийгээд бүрэлдэн тогтсон болон хувьсан өөрчлөгдөх зүй тогтоол, түүнийг ардын аж ахуйд хэрхэн яаж хэрэглэх зэргийг судлах ухаан): **эрдэс бордоо** (их ургац авахын тулд газрын хөрсийг бордох эрдэс эд).

ЭРДЭХ ямар нэгэн юманд түшиглэж оморхох, чадамгайрах, бардамнах; *эрх тушаалдаа эрдэх; эрдэм чадалдаа эрдэх; эд хөрөнгөндөө эрдэх.*

ЭРЖИГ а м ь т а н элжигтэй адил болоод салаа туурайтай, бөхөн шиг эвэртэй нэгэн зүйл гөрөөс, ганц эвэртэй ч байдаг.

ЭРЖИН тана.

ЭРЛИЙЗ 1. хоёр өөр үндэстэн ястны хоорондоос гарсан хүн; 2. хоёр өөр үүлдрийн дундаас гарсан мал, ургамал.

ЭРЛИЙЗЖИХ мал ургамлын эрлийз байдалтай болох.

ЭРЛИЙЗЖҮҮЛЭХ эрлийзжихийн үйлдүүлэх хэв.

ЭРЛЭГ 1. ш а ш и н нас нөгчсөн хүний урд төрөлдөө үйлдсэн сайн муу үйлийн үр боловсролыг ялгаж шүүн шийтгэгч; 2. ш и л ж с э н хөнөөл бүхий, дайсан; *хайрга бол гутлын эрлэг; чоно бол малын эрлэг.*

ЭРМЭГ 1. үр төл төрөхгүй амьтан; *эрмэг гүү;* 2. эрэмгий чадамгай.

ЭРМЭЛ эрж хайж олох баялаг, юмс.

ЭРМЭЛЗЛЭГ эрмэлзэх зүйлийн нэр; **хүсэл эрмэлзлэг** х о р ш.

ЭРМЭЛЗҮҮЛЭХ эрмэлзэхийн үйлдүүлэх хэв.

ЭРМЭЛЗЭЛ эрмэлзсэн нь; **хүсэл эрмэлзэл** х о р ш.; *шинийг санаачлах эрмэлзлийг дэмжих ётой.*

ЭРМЭЛЗЭХ 1. хүсэх ээрэх, горилох; *малчдад гарын авлага болох нэг зүйл бичихийг би эрмэлзэж байна;* 2. эрэмцэх.

ЭРМЭЭ у р г а м а л нутаг бууцанд ургадаг, бүдүүн голтой, үр нь сүүмгэр, өнгө нь хөхөвтөр, нилээд өндөрхөн нэгэн зүйл шарилж.

ЭРС I 1. шулуун цэх; 2. ш и л ж с э н үйл ажилд шууд шийдвэртэй; *эрс тэмцэх; эрс хэлэх; эрс хориглох; эрс шийдвэр; эрс шийдвэртэй; эрс хүн; эрс зориг; эрс шийдэмгий;* **эрс чиг** (а. хүний зан авир шудрага шулууны нь; б. шулуун цэх ба ойр татуу); **эрс тэс** (а. эрс тасархай; б. чанх өөр); **эрс харах** (а. эгцлэн харах; б. зовуурлахгүй харах): 3. юмны эгц, шулууны нь; *эрс өндөр уул; эгц эрс зам; эрс чиг; эрс шулуун;* ☆ **эрс тасархай** (олны дотроос онцгой ганцаараа юм).

ЭРС II хэл зүйн хүйсийн айн нэг зүйл, саармаг; *эрс хүйст үг; эрс хүйс.*

ЭРС III: **эрс буурцаг** у р г а м а л буурцгийн нам, баахан бяцхан, улаан цагаан хоёр зүйл бий.

ЭРСДҮҮЛЭХ эрсдэхийн үйлдүүлэх хэв.

ЭРСДЭХ I хэтэрхий эрс болох.

ЭРСДЭХ II хэлмэгдэх, нэрвэгдэх; *хилс хэрэгт эрсдэх; галын аюулд эрсдэх.*

ЭРСЛҮҮЛЭХ эрслэхийн үйлдүүлэх хэв.

ЭРСЛЭГ а м ь т а н өнгө шар, маш урт ганц эвэртэй бөгөөд эврийн үзүүр нь хурц бөгөөд судалтай нэг зүйл араатан, арслантай хэрэлдэн тэмцэх зангай гэдэг.

ЭРСЛЭН а м ь т а н Сибирийн арсланы нэр, хүч их, биеийн үс охор, хүзүүний үс сахлаг.

ЭРСЛЭХ 1. муруй юмны эгцрэх, түвшрэх, эрс болох; 2. зам мөрийн шулуун цэх болох; *зам эрсэлж явах;* 3. ш и л ж с э н сэтгэл зорилго шийдэж шулуудах; *санаа эрслэх; эрслэн харах.*

ЭРТ (ЭН) 1. цаг хэмийн багцааны урьдах хувий нь; *өглөө эрт; өдөр эрт; хавар эрт; өвөл* эрт; эрт босох; эрт явах; 2. маш урдын цаг, эрт урьдын хэрэг ,эрт цагийн юм; **эрт урьд** х о р ш.; *эртний ном; эртний бичээс; эртний Монгол орон; эртний хот балгад; эртний түүх;*

эртнээс эдүгээ хүртэл; эрт урьд нэгэн эмгэн өвгөн хоёр байжээ (үлгэр); **эртний судлал** (эртний хүмүүсийн ахуй амьдрал, соёлыг тэдний үлдээсэн эд уурсаар шинжлэн судлах ухаан; *эртний судлалын шинжилгээний анги*); **эртний судлагч** (эртний судлалын мэргэжилтэн); **эртний амьтны судлал** (чулуужсан буюу олвор амьтан, ургамал судлах ухаан); **эртний амьтан судлалч** (эртний амьтдын судлалд мэргэжсэн хүн).

ЭРТГЭР юмны дүр байдал хэвийн жишээнээс дээш матигар; *эртгэр хушуутай гутал; эртгэр хамартай амьтан.*

ЭРТДҮҮЛЭХ эртдэхийн үйлдүүлэх хэв.

ЭРТДЭХ хэтэрхий эрт болох; юмны зохист цагаас урьд болох; *бидний явах арай л эртдэх шиг бололтой.*

ЭРТЛҮҮЛЭХ эртлэхийн үйлдүүлэх хэв.

ЭРТЛЭХ үйл ажилд санаатайгаар эрт хөдлөх; *энэ өглөө эртлэж босов.*

ЭРТТЭХ улмаар эрт болох.

ЭРТҮҮД я р и а эртээр.

ЭРТҮҮР я р и а эртээр.

ЭРТХЭН баахан эрт, нилээд эрт; *эртхэн хөдөлнө шүү.*

ЭРТЭВТЭР нилээд эрт, арай эрт.

ЭРТЭГНЭХ эртгэр юмны эртэг эртэг хийх.

ЭРТЭГЧИН I сүүлт зээрийн шүдлэн насны шаргачин.

ЭРТЭГЧИН II: **эртэгчин нум** нумны хөвч нь хоёр хичрийн хооронд тэвхэнд дэлдэхгүйгээр хийсэн нум.

ЭРТЭД 1. эртээр; *эртэд уулзсан; эртэд ярилцаж шийдвэрлэсэн;* 2. эрт урьд.

ЭРТЭЙ эр чадалтай; *юм өргөж байгаа нь эртэй хүний шинжтэй байгаа биз дээ.*

ЭРТЭЛЗЭХ эртгэр юмны эртэс эртэс хийх.

ЭРТЭТГЭХ эрт болгох, эртдэхэд хүргүүлэх.

ЭРТЭЧ өглөө эрт босох ба үйл ажлыг эрт эвдан хийх зантай; *эртэч хүн.*

ЭРТЭЧЛЭХ эртчээр ажиллах.

ЭРТЭЭД эртээр.

ЭРТЭЭР I эрт гэгчин; *өглөө эртээр босох.*

ЭРТЭЭР II нилээд урьд, хэдийн; *эртээр чингэж ярилцсан; эртээр авчирсан.*

ЭРҮҮ (Н) I 1. хүн амьтны толгойн, амнаас дооших хэсэг; **эрүү толгой** х о р ш.; *эрүүний шүд; эрүүний углуурга;* **эрүү засах, эрүү заах** (амьтны эрүүг толгойноос нь салгах): **эрүү зуурах** (шүд зуурах); 2. зуухны аман этгээдэд гал үнс зэргийг тосч тавих юм; *зуухны эрүү; эрүү гаргуул;* 3. хавхны тархийг тосч тавьсан матигар мод; *хавхны эрүү;* 4. х у у ч и р с а н эхнэр хүний дээлийн ханцуй дээрх өөр өнгийн юмаар хийсэн оруулга; *дээлийн эрүү;* 5. өндөрлөг газрын аюухан бууж ирсэн шүвтрага болох газар; *уулын эрүү; Ханангийн эрүүд намаржина.*

ЭРҮҮ II гэмт хэрэг үйлдэгсдийг залхаах цааз; **эрүү цааз, эрүү хор** х о р ш.; **эрүү шүүлт** х у у ч и р с а н (гэм хэрэгт холбогдогчдоос өчиг учрыг илтгэн гаргуулах ба цээрлүүлэхэд хэрэглэх банз шаахайн зэрэг хэрэглэл); **эрүү тулгах** х у у ч и р с а н (эрүү шүүлт хүчдэн хэрэглэх); **эрүүгийн хэрэг** (гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хуулийг иш татаж шийтгэвэл зохих гэмт хэрэг); **эрүүгийн хууль** (чухам ямар хэргийг гэмт хэрэгт тооцох ба гэмт хэрэг үйлдэгсдэд ямар ял шийтгэл хүлээлгэхийг зааж тогтоосон хууль).

ЭРҮҮДҮҮЛЭХ 1. эрүүдэхийн үйлдүүлэх хэв; 2. эрүүдэгдэх.

ЭРҮҮДЭГДЭХ эрүүдэхийн үйлдэгдэх хэв.

ЭРҮҮДЭЛ эрүүдэх үйлийн нэр.

ЭРҮҮДЭХ х у у ч и р с а н гэмт хэрэг үйлдэгчдэд өчиг мэдүүлгийг тулган байцаах, эрүү шүүлт тулган хүлээлгэх.

ЭРҮҮЛ амьтны ухаан мэдрэл бүрэн бүтэн, өвчин эмгэггүйгий нь; **эрүүл энх, эрүүл мэнд, эрүүл эсэн, эрүүл саруул** х о р ш.; *эрүүл хүн; эрүүл мал; эрүүл ухаан; эрүүл биенд саруул ухаан хэрэгтэй; жаргалыг хүсвэл эрүүлийг хүс; жаргалангийн дээд нь эрүүл энхийн жаргалан.*

ЭРҮҮЛЖИХ эрүүл болох, эрүүлших.

ЭРҮҮЛЖҮҮЛЭХ эрүүлжихийн үйлдүүлэх хэв.

ЭРҮҮЛЧ аливаа юмны үнэрээр хөөж замнах сургуультай нохой.

ЭРҮҮЛШИХ эрүүл шинжтэй болох, эрүүлжих.

ЭРҮҮЛШҮҮЛЭХ эрүүлшихийн үйлдүүлэх хэв.

ЭРҮҮЛЭХ I 1. х у у ч и р с а н албадах, дарангуйлан зоволж цухалдуулах; 2. эрүүдэх. ᠡᠷᠦᠦᠯᠡᠬᠦ • ᠡᠷᠦᠦᠯᠡᠬᠦ

ЭРҮҮЛЭХ II 1. эрэхийн үйлдүүлэх хэв; 2. эрэгдэх. ᠡᠷᠦᠦᠯᠡᠬᠦ

ЭРХ I нийгэм дахь хүмүүсийн харьцааг зохицуулан төр засгаас тогтоон хамгаалах хэм хэмжээний цогц; *улсын эрх; сурах эрх; амрах эрх; эрх ашиг; эрх тэгш; эрх тэгшгүй; эрх чөлөөний тэмцэл; эрх чөлөөний хөдөлгөөн;* **ардын эрх** (иргэний эрх): **сонгуулийн эрх** (сонгох, сонгогдох эрх); **хувийн эрх** (ард иргэдэд хууль ёсоор олгосон эрх); **эрх чөлөө** (бүх улс нийгмээрээ буюу улсын хүн ард тусбүр хийгээд мөн ямар нэгэн ангийн улс төр, олон нийт, албан амин алив үйл явдал, ажил төрөлдөө саад, садаа, хавчлага хязгаарлал үзэхгүй, өөрийн сэтгэл зоригийг илэрхийлэх боломж); **эрх сүр** (улс аймаг, хүн ардын хүч чадвар зэрэгтээ эрдэлхийлж бусдыг зүй бусаар эзэрхэх айлгах төлөв); **эрх алдах** (эрх мэдлээ бусдад булаагдаж хасагдах зэргээр өөрийн мэдэлгүй болох); **эрх хасах** (аливаа үйл явдалд ёс зүйн дотор өөрийн дураар явж үйлдэж болох эрх мэдлийг ямар нэгэн шалтгаанаар хууль ёсоор хязгаарлах); **эрх олох** (бусдад алдагдсан эрхээ эгүүлэн авах буюу тувтам эрхтэй болох); **эрх барих** (улс, аймгийн ба айл гэрийн аливаа хэрэг зүйлийг эрхлэн мэдэж тэргүүлэх); **эрх тэмцэх** (эрх мэдэл булаалдах); **эрхэнд орох** (бусдын эрхэнд автагдах); **эрх булаах** (бусдын эрхийг шилжүүлэн авч эзлэх); **эрхийг эвдэх** (хууль ёсоор эдэлбэл зохих эрхийн заримыг буюу бүрнээ хасах); **эрхийг эзэрхэх** (бусдын эрхийг сүр хүчээр буюу арга залиар булаан авч хэрэглэх, эзэмших); **эрхийг эзлэх** (эрх барих буюу эрхийг эзэрхэх); **эрхээр болгох** (а. үйл хэргийг өөрийн зориг санал тийш татан аваачих: б. хэргийг шийдвэрлэх шийтгэхэд зүй зохисыг үзэж улиран аваачих); **эрхээр аваачих** (албан тушаал, эрх сүр, эрдэм ухааны зэргээр ялан дагуулж ямар нэгэн үйл ажлыг өөрийн дур саналаар болгох); **эрх мэдэл** (ямар нэгэн үйл ажлыг өөрийн санасан бодсоноор таслах шийдвэрлэх хувь мэдэл); **эрх хэмжээ** (хүний эзэмшин эдэлж болох эрх мэдэл); **эрх дарх** (хүний гавьяа зүтгэлд сайшаан шагнаж олгосон эрх). ᠡᠷᠬᠡ

ЭРХ II амьтны тоглох наадахдаа маш дуршилтайгий нь; *эрхийг сурахаар бэрхийг сур* х у у ч; **эрх хүүхэд** (эцэг эх, ураг садан нь тансаглан зоргоор нь байлгах хүүхэд); **эрх танхи, эрх танхил** (хүүхэд залуус ба морь малын хүнд хүчир ажил явдал үзээгүйгий нь): **эрх эмзэг** (а. энхрийлэгдсэн хайрлагдсан юм; *эрх эмзэг хүүхэд; эрх эмзэг эд;* б. биеэ хэтэрхий хайрламтгай; *эрх эмзэг хүн);* **эрх дураар** (бусдаас айх эмээхгүй зоримгоор аашлах);

ЭРХ III: **эрх ялуу** тэрэгний ялуугийн урд хойт хоёр захын ялуу мод.

ЭРХ IV тоог тэмдэглэх хэрэгсэл, юмны тоог авах ба зүүлт чимэгт хэрэглэнэ. ᠡᠷᠬᠡ

ЭРХБИШ аливаа юмыг гүйцэтгэх бүтээхийг шууд эрмэлзэх утгаар хэрэглэх үг; *миний урьд хэлсэн зүйлийг эрхбиш бодолцох хэрэгтэй; энэ хэрэг дээр чи эрхбиш голлож хийх нь чухал.* ᠡᠷᠬᠡᠪᠢᠰᠢ

ЭРХГҮЙ 1. эрх мэдэлгүй; 2. яавч, заавал, аливаа юм, үйл ажлын зайлшгүй болох, болгохы нь заахад хэрэглэх үг; *тэнгэр үүлшиж байна, эрхгүй бороо орно; чи энэ ажлыг өнөөдрийн дотор эрхгүй хийж дуусга.* ᠡᠷᠬᠡᠶ᠋ᠢ ᠦᠭᠡᠢ

ЭРХИЙ 1. хүний гар хөлийн нэгдүгээр том хуруу; *эрхий хуруу;* **эрхий дарах** (а. юмыг хуваахад сайныг үзэж биед болгохыг буюу юмыг аргацааж хэмнэн үлдээж хожим хэрэглэхэд бэлтгэх; *эрхий дарж, хуруу хэмжих;* б. аливаа батлах зүйлд гарын эрхийний зургийг гаргаж дарах; *эрхий дарж батлах);* 2. шувууны дөрвөн хумсны хойтох нэг хумс; *эрхий хумс;* 3. хавх занга зэргийг зүүхэд торгож тогтоох оньс; *хавхны эрхий; занганы эрхий.* ᠡᠷᠬᠡᠶ᠋ᠢ

ЭРХИЙВЧ хүний эрхий хуруунд өмсгөн хэрэглэх юмны нэр, харвахад нумны хөвчийг тээглүүлэн жийрэглэх ба гоёж чимэглэхэд хэрэглэх хоёр зүйл байдаг: *эрхийвч хийх.* ᠡᠷᠬᠡᠶ᠋ᠢᠪᠴᠢ • ᠡᠷᠬᠡᠶ᠋ᠢᠪᠴᠢ

ЭРХИЙВЧЛҮҮЛЭХ эрхийвчлэхийн үйлдүүлэх хэв. ᠡᠷᠬᠡᠶ᠋ᠢᠪᠴᠢᠯᠡᠭᠦᠯᠬᠦ • ᠡᠷᠬᠡᠶ᠋ᠢᠪᠴᠢᠯᠡᠭᠦᠯᠬᠦ

ЭРХИЙВЧЛЭХ 1. эрхийвчийг хуруунд өмсөх; 2. харвах зэвсгийг онилж татахад эрхийгээр чагтлан торгох. ᠡᠷᠬᠡᠶ᠋ᠢᠪᠴᠢᠯᠡᠬᠦ • ᠡᠷᠬᠡᠶ᠋ᠢᠪᠴᠢᠯᠡᠬᠦ

ЭРХЛҮҮЛЭХ I эрхлэх I-ийн үйлдүүлэх хэв; *чухал ажлыг эрхлүүлэх.* ᠡᠷᠬᠡᠯᠡᠭᠦᠯᠬᠦ

ЭРХЛҮҮЛЭХ II эрхлэх II-ын үйлдүүлэх хэв, хүүхэд багачуудын эрхлэхийг зөвшөөрөх, дураар нь тавиж мэтээр хориглох саатуулахгүйгий нь; *ганц хүүгээ эрхлүүлсээр байгаад танхай болгох юм биш биз дээ.* ᠡᠷᠬᠡᠯᠡᠭᠦᠯᠬᠦ

ЭРХЛҮҮЛЭХ III эрхлэх III-ын үйлдүүлэх хэв. ᠡᠷᠬᠡᠯᠡᠭᠦᠯᠬᠦ

ЭРХЛЭГЧ ямар нэгэн албан үүргийг хариуцсан хүний албан тушаал; *хэлтсийн эрхлэгч; аж ахуйн эрхлэгч.* ᠡᠷᠬᠡᠯᠡᠭᠴᠢ

ЭРХЛЭХ I 1. ямар нэгэн үйл ажлыг бие дааж хариуцан гүйцэтгэх; *миний эрхлэх ажил бол... манай хэлтсийн эрхлэх зүйл нь;* 2. аливаа нэг ажлыг дагнаж гүйцэтгэх; *би-малын ажлыг эрхэлдэг хүн; тэр бол тариалангийн ажлыг эрхлэн хийдэг хүн.*

ЭРХЛЭХ II 1. хүүхэд багачууд, эцэг эх ах ихэстээ тунирхан аашлах; *аавдаа эрхлэх;* 2. хүн амьтны тоглож наадах; **эрхлэх тоглох, эрхлэх наадах** х о р ш.; 3. тэжээврийн амьтад, эзэмшсэн дассан хүндээ саймсран наадаж аашлах; *нохой эрхлэх; хурга эрхлэх.*

ЭРХЛЭХ III эрхийг хүзүү энгэр зэрэгт зүүж чимэглэх; *эрх эрхлэх.*

ЭРХРЭХ хүний ялтарсан, шархалсан газар зэрэгт хорсон чинэрч өвдөх; *эрхэрч өвдөх; эрхэрч шархирах.*

ЭРХТ эрхтэй.

ЭРХТЭЙ эрх мэдэл бүхий; *бүрэн эрхтэй; тэгш эрхтэй; таслах эрхтэй; сонсох эрхтэй.*

ЭРХТЭН I их эрх мэдэлтэй этгээд; *цэргийн эрхтэн;* **эрхтэн дархтан** (хүн ардын дотроос эрх мэдэл онц тасархай буюу бие хөрөнгөнд ногдох албан татварыг хэлтрүүлэгдэх хөнгөлөгдөх зэргээр дотночлогдсон хүн).

ЭРХТЭН II хүн амьтны мөч гишүүн мэтийн бие махбод; *хөдлөх эрхтэн; бэлгийн эрхтэн; эрхтэн дутуу;* **таван эрхтэн** (хүн амьтны бие, нүд, чих, хэл, хамар; *хүрэлцэх эрхтэн-бие; үзэх эрхтэн-нүд; сонсох эрхтэн-чих; амтлах эрхтэн-хэл; үнэрлэх эрхтэн-хамар);* **эрхтний гар у р г а м а л** (а. арьс нь шар, дотор нь цагаан, үзүүр этгээд зангидсан гар мэт нэгэн зүйл жимс; б. хүний гартай төстэй нэг зүйл ургамал, эмнэлэгт хэрэглэдэг, ванлаг ч гэдэг).

ЭРХТЭН III Дорно зүгийн зурхайн ёсны жил сар, өдөр цагийг нэжгээдээр тус тус эзлүүлэн хуваарь нэрийдэх арван хоёр амьтад; хулгана, үхэр, барс, туулай, луу, могой, морь, хонь, бич, тахиа, нохой, гахай эдгээр болно.

ЭРХҮҮД Христосын шашинтныг нэрлэх нэр.

ЭРХҮҮЛЭХ I эрхэх I-ийн үйлдүүлэх хэв.

ЭРХҮҮЛЭХ II эрхэх II-ын үйлдүүлэх хэв.

ЭРХЧЛЭХ өөрийн эрхийн хирээр албан үүргээ гүйцэтгэн явах.

ЭРХШИЛ эрхших үйлийн нэр; *эрхшил ихтэй; эрхшил нь нэндэх.*

ЭРХШИХ *хүн* амьтны эрх зоргоор байсаар амтших буюу юманд дадах занших; *дураар жаргаж эрхших; үйл ажилд дадаж эрхших; юманд идээшиж эрхших.*

ЭРХШЭЭЛ эрхшээх үйлийн нэр, эрхэнд авахы нь; *эрхшээлд нь автагдах; эрхшээл нь хэтрэх; эрхшээлдээ авах; эрхшээлдээ хураах.*

ЭРХШЭЭХ юманд эрхшиж, эрхийг олох, эрхэндээ авах.

ЭРХЭВЧ юмыг чангарулах мушгиур зэрэг хэрэгсэл; *хөгжмийн утсыг чангаруулах эрхэвч.*

ЭРХЭМ 1. юмны чухал хэрэглэгдэх онц хэрэг тус бүхийг буюу хэрэг тус илүүцтэйгий нь; *алт бол эрхэм эд мөн; эм эрхэм тустай; эрхэм сайн; эрхэм чанар;* 2. хүний хүндэтгэл; *эрхэм нөхөд; эрхэм сайд; эрхэм ах;* **эрхэм чигийрмаа цэцэг у р г а м а л** (навч нэг хоёр тохой урт, мөнх ногоон, шар ногоон цэцэгтэй, хэлтэс уртуулаг шуумгай, үнэр анхилам болоод нэмүүн, нэг эгшинд нэг хүйс цэцэглэнэ).

ЭРХЭМЛҮҮЛЭХ I. эрхэмлэхийн үйлдүүлэх хэв; 2. эрхэмлэгдэх.

ЭРХЭМЛЭГДЭХ эрхэмлэхийн үйлдэгдэх хэв.

ЭРХЭМЛЭХ аливаа юмыг онц чухал, эрхэмд үзэх; *сурахыг эрхэмлэх; ажил хөдөлмөр хийхийг эрхэмлэх; ариун цэврийг эрхэмлэх; эрхэмлэн хүндэтгэх.*

ЭРХЭМСЭГ 1. хүн амьтны эрх зантайгий нь; *эрхэмсэг хүн; эрхэмсэг хүүхэд;* 2. хүндэтгэл үг; *эрхэмсэг ноён; эрхэмсэг дарга.*

ЭРХЭМСЭГЛҮҮЛЭХ эрхэмсэглэхийн үйлдүүлэх хэв.

ЭРХЭМСЭГЛЭХ эрхэмсэг зан байдал гаргах.

ЭРХЭН 1. эрхэм, голч юмны чухал ихэнх; *тэдний эрхэн нь тэр мөн; эдгээрийн дотор эрхэн нь юу вэ?* 2. хүндэтгэл үг; *эрхэн хүн; эрхэн нөхөр.*

ЭРХЭС I эр булга; эрхэс хэрээ а м ь т а н (суурин газарт орших нэгэн зүйл хэрээ, сүрэглэн явна).

ЭРХЭС II огторгуйд орших одон гариг сэлтийн нийт нэр; *тэнгэрийн эрхэс.*

ЭРХЭХ I хэвийн зан байдал хувьсаж дордох; *хүний сэтгэл урмас гомөрхон, ааль явдлаа муутгаж эрхэх; адгуусан амьтны ярдаглан*

гөжүүрхэж элдэв муу зан гаргаж эрхэх.

ЭРХЭХ II зарим өвчин эмгэгийн үгдрэн хувирч дордох; *яр шарх хөндөгдөн эрхэх; хатиг эрхэх; хөх эрхэх.*

ЭРХЭЭХ эрхэхэд хүргүүлэх, эрхүүлэх.

ЭРХЭЭЧ 1. эрхэх зантай; *эрхээч хүн эмзэг;* 2. санаа сэтгэл хэлбэлзэн тогтууригүй хувирамтгай.

ЭРЦЭХ хадгалсан юмаа олохгүй эрэл болох.

ЭРЧ I утас дээс зэрэгт оруулж бэхэлсэн мушгиагий нь; *зөв эрч; буруу эрч; муу эрчтэй дээс; эрчий нь чангалах; эрч нь онцрох; эрчий нь харцулах; эрч оруулах.*

ЭРЧ II хүч, эрчим; **эрч хүч, эрч чадал** х о р ш.; *эрчээрээ гүйх; эрчтэй залуу; эрчиндээ явах; эрчээ хадгалах.*

ЭРЧГЭР үрчгэр.

ЭРЧИГНҮҮР хүүхдийн эргүүр тоглоом.

ЭРЧИЙДЭХ сум зэвийн үүсгэрийг залахад гарын хуруугаар тойруулан тэнсэж үзэх; *сум эрчийдэх.*

ЭРЧИЙЛГЭХ эрчийхэд хүргүүлэх, эрчгэр болгох.

ЭРЧИЙХ эрчгэр болох.

ЭРЧИМ I 1. энерги; *эрчим хүч;* 2. утас дээс зэрэг юмны чанга нийтгэсэн мушгисны нь.

ЭРЧИМ II үйл хэргийг хийж гүйцэтгэхэд хүчтэй, чанартай болгохы нь; *ажлын эрчмийг сайжруулах.*

ЭРЧИМГҮЙ I 1. эрчим хүчгүй, муу; 2. утас дээс зэрэг юмны мушгиа сул үлбэгэрий нь.

ЭРЧИМГҮЙ II хүн амьтны зориг муу сул.

ЭРЧИМЛЭХ I 1. эрчим хүч оруулах; 2. утас дээс зэрэгт эрч оруулах.

ЭРЧИМДЭХ II үйл явдлыг хийх бүтээхэд хүч чанар оруулах, сайжруулах.

ЭРЧИМНЭХ эрчимлэх.

ЭРЧИМТЭЙ I 1. эрчим хүчтэй, эрчим хүч бүхий; 2. утас дээс зэрэгт эрч бий.

ЭРЧИМТЭЙ II юмны хүчтэй чанартай; *сурталхухууллагын ажлыг эрчимтэй зохиох.*

ЭРЧИХ мартсан үйл явдлыг дахин дахин бодох, санах.

ЭРЧЛҮҮЛЭХ эрчлэхийн үйлдүүлэх хэв.

ЭРЧЛЭХ I утас дээс мэтийг нийтгэх, томох, эрч оруулах; *утас эрчлэх.*

ЭРЧЛЭХ II эрийн адил чадамгай байдал гаргах; 2. хүний эрийн зэрэгт хүрэх; 3. эрий нь ялгаж авах.

ЭРЧТЭЙ I эрч бүхий юм, эрч чангатай юм.

ЭРЧТЭЙ II хүчтэй, чадалгай.

ЭРШҮҮД шулуун шудрага, гүдэсхэн зан байдалтай; *эршүүд зантай хүн.*

ЭРШҮҮДЛЭХ эршүүд зан байдал гаргах.

ЭРЭВГЭНҮҮЛЭХ эрэвгэнэхийн үйлдүүлэх хэв.

ЭРЭВГЭНЭХ эрэвгэр юмны эрвэг эрвэг хөдлөх.

ЭРЭВГЭР сэрэвгэр; **эрэвгэр сэрэвгэр** х о р ш.; *эрэвгэр сэрэвгэр модтой; эрэвгэр сэрэвгэр өвс.*

ЭРЭГ I далай мөрний хөвөө, үүл хадын хажуу зэрэгт өнгийж тогтсон ирмэг: **эрэг нураа** х о р ш.; *голын эрэг; дэнжийн эрэг.*

ЭРЭГ II шураг зэрэг юманд гаргасан мушгимал суваг; **эрэг шураг** х о р ш.; *эрэгтэй хадаас;* **эр эрэг** (мөнхүү мушгимал суваг бүхий шураг); **эм эрэг** (шураг орох, мушгимал суваг бүхий зүйл).

ЭРЭГ III: **эрэг муриг** хүний ханигүй, элдэг биш зантайг нь.

ЭРЭГДҮҮЛЭХ эрэгдэхийн үйлдүүлэх хэв.

ЭРЭГДЭХ I шураг бүхий хадаас мэтийг мушгиж тогтоох буюу чангатгах.

ЭРЭГДЭХ II усны эрэг дагуу буух, байрлах.

ЭРЭГЛҮҮЛЭХ эрэглэхийн үйлдүүлэх хэв.

ЭРЭГЛЭХ эрэг гаргах; *усны урсгалд эвдэрч эрэглэх; нүд хонхойж эрэглэх.*

ЭРЭГМЭЛ эрэгдэг юм; **эрэгмэл шат** (эргэж гарах шат).

ЭРЭГНЭГ 1. байшингийн хэрэм туурганд хадсан юм хум тавих тавиур; 2. юм хум агуулах тавих хорго сав.

ЭРЭГТЭЙ эр хүн; *эрэгтэй хүн; эрэгтэй хүүхэд; эрэгтэй эмэгтэй ажилчид.*

ЭРЭГТЭЙЧҮҮД эрэгтэй олон хүн.

ЭРЭГЦҮҮЛЭХ эргэцүүлэх.

ЭРЭГЦЭГ мөгүү, мөрөгцөг; **эрэгцэг мөрөгцөг** х о р ш.; *голын эрэгцэг.*

ЭРЭГЦЭХ эргэцэх.

ЭРЭГЧИН зарим амьтны эрий нь; *эрэгчин тахиа;* **эрэгчин эмэгчин** (зарим амьтны эр эмийг хамтатган нэрлэх үг); ☆ **эрэгчин эмэгчнээ үзэх** (хүмүүс харилцан дийлэх дийлдэх, илүү дутуу болохыг ялгаж тэмцэлдэх)

ЭРЭЛТ эрэх үйлийн нэр, хүсэлт; **эрэлт хүсэлт** х о р ш.; *эрэлт шаардлага; малчдын эрэлт хүсэлтийг хангах.*

ЭРЭЛХҮҮ эрэлхэх зантай, дээрэнгүй зантай; *урьдын цагт ноёд баяд нар ядуу хүнд их эрэлхүү байж билээ.*

ЭРЭЛХҮҮЛЭХ эрэлхэхийн үйлдүүлэх хэв.

ЭРЭЛХЭГ 1. эрэлхүү; 2. хүчирхэг; **эрэлхэг хүчирхэг** х о р ш.; *эрэлхэг чадалтай улс; эрэлхэг зоригтой хүн; колони-хараат орны ард түмний эрэлхэг тэмцэл.*

ЭРЭЛХЭХ бусдад эрдэж, оморхон дээрэлхэх, эрэлхүү зан байдал гаргах.

ЭРЭМГИЙ чадамгай, хүчирхэг, зориг сайтай; *эрэмгий зоригтой.*

ЭРЭМГИЙДҮҮЛЭХ эрэмгийдэхийн үйлдүүлэх хэв.

ЭРЭМГИЙДЭХ хэтэрхий эрэмгий болох.

ЭРЭМГИЙЛЭХ эрэмгий зан байдал гаргах.

ЭРЭМГЭЛЗЭХ эрмэлзэх, хүсч горилох.

ЭРЭМДЭГ 1. хүний ямар нэгэн эрхтэн дутуу; *эрэмдэг дутуу;* 2. хуучин өвчинд баригдаж дорой буурай болсны нь; *эрэмдэг болсон амьтан;* **эрэмдэг зэмдэг, эрэмдэг зэрэмдэг** (хүн амьтны биед тогтмол өвчтэй, дутуу тахир болсны нь).

ЭРЭМХИЙ эрэмгий.

ЭРЭМЦЭЛ эрэмцэх үйлийн нэр.

ЭРЭМЦЭХ юмыг санаанд маш хайрлаж, салж түвдэхгүй, ангижран чадахгүй болох.

ЭРЭМШИЛ эрэмших үйлийн нэр.

ЭРЭМШИХ 1. шийтгэл цээрлэл аваагүйдээ амтшиж оморхох; 2. урьд болж байсан үйл явдалд эрдэж, ахиж цаашилж даврах; **эрдэх эрэмших** х о р ш.,

ЭРЭМШҮҮЛЭХ эрэмшихийн үйлдүүлэх хэв.

ЭРЭН он гооллыг зуу буюу жараар нэг үе болгож тоолох; *манай эрэнгийн өмнө хэдий үед билээ? эрэн цагийн өөрчлөлт хувьсал.*

ЭРЭНД у р г а м а л зарим халуун газар ургадаг, өргөстэй бөгөөд тослог үртэй нэгэн зүйл ургамал: **эрэндийн тос** (эрэндээс ялгаруулан авдаг өтгөн тос, саван хийх, резиний үйлдвэр, эмнэлэг зэрэгт хэрэглэнэ).

ЭРЭНЦЭХ хоёр хөл халалцан, урагш харайлан наадах.

ЭРЭХ I 1. олс дээс зэрэг оосроор юмыг боож мушгин чангаруулах; 2. юмыг эрэг шургаар эрэгдэж хадах, тогтоох.

ЭРЭХ II мэдье олъё гэж хайх сурвалжлах; **эрэх сурах, эрэх хайх, эрэх сурвалжлах** х о р ш.; *хэрэг явдлын зүй зохисыг хянан эрэх; эд хөрөнгийн зүйлийг ашиглах хэрэглэхийн учир эрэх; завхсан гээгдсэн юмыг олох тохиолгохоор эрэх; арга эрэх;* **эрэх сурах** (эрж сурвалжлах; *эд юм эрж сурах; алдуул малыг эрж сурах);* ☆ **амрыг эрэх** (амар мэнд асуух; *багшийн амрыг эрж хүндлэн ёслов).*

ЭРЭХ III газрыг нүхлэн ухах; *газар эрэх; эрж малтах.*

ЭРЭХ IV эмэгтэйчүүдийн хөх булчирхайтаж өвдөх, эрхэх ч гэдэг; *хөх эрэх.*

ЭРЭЭ I цээр; юмнаас сэжиглэх жигших, нэрэлхэх, ичингүүрэх зэргээр цээрлэхий нь; **эрээ цээр** х о р ш.; *эрээ цээргүй аашлах;* **эрээгээ алдах** (а. буслын эрхшээлд автагдах, хамаагаа алдах, хээгээ алдах; б. жигших цээрлэх, ичингүүрэхийг мэдэхгүй болох).

ЭРЭЭ II загасны заарцаг.

ЭРЭЭВЭР: эрээвэр хурааваp энд тэндээс үүж түүж олсон юм, янз бүрийн юм.

ЭРЭЭГҮЙ эрээ цээр байхгүй, хамаагүй, хээгүй, жигших цээрлэхийг үл мэдэхий нь.

ЭРЭЭГЧ эрээн зүсмийн эм амьтан; *эрээгч үнээ.*

ЭРЭЭДҮҮЛЭХ эрээдэхийн үйлдүүлэх хэв.

ЭРЭЭДЭС юмыг эрж чангатгах хэрэгсэл; *ачааны татлага даруулга чангалах эрээдэс; хөрөөний эрээсийг мушгиж чангаруулах эрээдэс.*

ЭРЭЭДЭСЛЭХ эрээсээр чангалах.

ЭРЭЭДЭХ бусдын үйл ажилд сэжиг таамнал төрж учрыг лавтлан мэдэхийн тул ажиг тавьж оролдох; *намайг юуны учир эрээдэж байгаа юм бэ?*

ЭРЭЭЛЖ өнгө алаглаж хийсэн нарийн урт зурвас торгомсог эд.

ЭРЭЭЛЖЛҮҮЛЭХ эрээлжлэхийн үйлдүүлэх хэв.

ЭРЭЭЛЖЛЭХ нүдний үзэх нь жирэв жарав болох; *нүд эрээлжлэх.*

ЭРЭЭЛҮҮЛЭХ эрээлэхийн үйлдүүлэх хэв.

ЭРЭЭЛЭХ I 1. юмны алагтан цоохортох; *газар эрээлэн харагдах;* 2. юмыг алаг эрээн болгох; *эрээлж будах.*

ЭРЭЭЛЭХ II 1. цээрлэх жигших, сэжиглэх, таамнах; **эрээлэх цээрлэх, эрээлэх зочирхох, эрээлэх нэрэлхэх** х о р ш.; *эрээлж санах зүйл юун;* 2. зочирхох, хүнийрхэх; *та битгий эрээлээрэй, сайн идэж уугаарай.*

ЭРЭЭН 1. юмны **өнгө зүс жижиг** алаг цоохры нь; **эрээн мираан х о р ш.**; *эрээн алаг; эрээн цоохор; эрээн даавуу;* **эрээн тарлан** (юмны өнгө зүс алаг ба цас ургамал зэргийн юмны энд тэнд алаг цоогийг нь); 2. ш и л ж с э н хүний муу санаа; *хүний эрээн дотроо, могойн эрээн гаднаа* з ү й р.

ЭРЭЭНДҮҮЛЭХ эрээндэхийн үйлдүүлэх

ЭРЭЭНДЭХ хэтэрхий эрээн болох.

ЭРЭЭНТҮҮЛЭХ эрээнтэхийн үйлдүүлэх хэв.

ЭРЭЭНТЭХ эрээн болох, эрээлэн үзэгдэх, цоохортох; *газар эрээнтэх; цэцэг навч эрээнтэх.*

ЭРЭЭС I юмыг эрж чангаруулахад хэрэглэх оосор; *хөрөөний эрээс; шатны эрээс.*

ЭРЭЭС II эрэг шургийн эргүүлгэн суваг.

ЭРЭЭЧИХ 1. байн байн эрээлэх; 2. бичих зурах зэрэгт бүдүүвчлэн таталж дүрэмнэх; хүүхэд **багачуудын хэрэггүй юм сараачиж** зуралхийлэх; **эрээчих сараачих х о р ш.**,

ЭРЭЭЧҮҮЛЭХ эрээчихийн үйлдүүлэх хэв.

ЭС I аливаа махбодын байгууллын энгийн, нэгж; *ганц эст амьтан; олон эст амьтан ургамал.*

ЭС II хориглох сул үг, үл; *эс гүйцэв; эс мэдэв; эс тоожээ.*

ЭСВЭЛ нэг бол, үгүй бол; *чи явах уу, эсвэл би явъя.*

ЭСВЭЭС б и ч г и й н эсвэл.

ЭСГИЙ 1. малын үс ноосоор ширэлдүүлэн хийсэн эд; **эсгий хийх** (эсгий үйлдвэрлэх); **эсгий татах** (эсгийг чирч өнхрүүлэх): **эсгийний бул** (эсгийн голд углах мод); **эсгийний гөд** (эсгийг ороож хийх уртхан мод); **эсгий дарах** (эсгий элдэж боловсруулах); 2. үс ноосоор эсгий мэт хийсэн элдэв эд; *эсгий гутал; эсгий малгай;* 3. эсгийгээр хийсэн зүйл; *эсгий оймс эсгий өрх; эсгий тохом.*

ЭСГҮҮЛ эсвэл.

ЭСГҮҮР I 1. юмыг эсгэх зүсэх зэрэгт хэрэглэх хутга хянгар; 2. х у у ч и р с а н хутганы хүндэтгэл; 3. жижигхэн хутга; *эсгүүр хутга.*

ЭСГҮҮР II идээний зүйлийг исгэх, хөөлгөхөд хэрэглэх хөрөнгийн зүйл; *мантууны эсгүүр.*

ЭСГҮҮЛЭХ 1. эсгэхийн үйлдүүлэх хэв; 2. эсгэгдэх.

ЭСГЭЛ 1. эсгэх үйлийн нэр; 2. юмыг исгэх хөрөнгө.

ЭСГЭЛЭН айргийн амт мэт амт; *эсгэлэн тараг;* эсгэлэн ус (элдэв ногоо жимсний зүйлээр эсгэж хийсэн ундаа); **эсгэлэн шүүс** (амуу будааны зүйлээр эсгэж хийсэн ундаа).

ЭСГЭМЭЛ эсгэсэн юм; *үхрийн эсгэмэл ундаа.*

ЭСГЭХ I идээ ундааны зүйлийг хувилгаж эсгэлэн болгох; *айраг эсгэх; мантуу эсгэх; эсгэх хөрөнгө.*

ЭСГЭХ II 1. хувцас эдлэл зэргийг хийхэд уг байдал дүрмэнд тохируулан хайчлах, огт лох; *дээл эсгэх; гутлын түрий эсгэх;* 2. ирт юмны өчүүхэн хэрчих огтлох; **эсгэх огтлох х о р ш.**; *гараа эсгэх.*

ЭСЛЭГ 1. ургамлын эсийн бүрхүүлийг бүрэлдүүлэх бодис; 2. хүн амьтны эржгэр хөлбөх нэхдэс.

ЭСНЭХ х у у ч и р с а н хүндэтгэвэл зохих хүний төрөх.

ЭСРЭГ 1. эгц, нааш хандах, эргэх эгэхий нь; *нүүр нүүрээрээ эсрэг харалцах;* **эсрэг хандах** (а. аливаа юмны эгц өөдөөс хандах; б. урвах); 2. аливаа хөдөлгөөний өмнөөс, урдаас, өөдөөс; *эсрэг салхилах; эсрэгээс ирэх;* 3. эрс зөрөөтэй, дайсагналтай, тэрс; **эсрэг тавих** (сөрөг тавих; *хуучин нийгмийн үлдэгдлийн эсрэг тавих ухуулга таниулга);* **эсрэг бүлэг** (алив зүйлд харш санаа бодол бүхий бүлэг,

хуйвалдаан): **хувьсгалын эсрэг** (хувьсгал эсэргүүцсэн тэрс үзэл санаа арга явууллага); **төрийн эсрэг** (төрийг эсэргүүцсэн тэрс үзэл санаа, арга явууллага); **шинжлэх ухааны эсрэг** (шинжлэх ухаанд тэрс муу үзэл санаа, ажиллагаа); **шашны эсрэг** (шашны сургаал ба шашны ёсны тэрс ажил явууллага; *шашны эсрэг суртал нэвтрүүлэг);* **эсрэг болсого** (алив үйл ажиллагааг дургүйцэн боссон болсого); **эсрэг тэсрэг** (а. нааш цааш; *эсрэг тэсрэг явалцах; эсрэг тэсрэг булаалдах;* б. ийш тийш; *эсрэг тэсрэг хандалцах; эсрэг тэсрэг гүйлдэх* в. өмнөөс, араас; *эсрэг тэсрэг салхилах; эсрэг тэсрэг зорчих;* г. эвлэршгүй, тэрс; *эсрэг тэсрэг тэмцэл);* **эсрэг атга** (хоёр гарын алгыг хавсран нийлүүлж атгасан хэмжээ).

ЭСХҮҮЛ эсвэл, эсгүүл; *та цай ууна уу эсхүүл айраг ууна уу.*

ЭСЭГ 1. эсгэлэн амттай ундаан; 2. айраг; *эсэг уух;* 3. эсгэсэн гурил.

ЭСЭЛ бодисын исэлдэх дундаж хэмжээ, исэл ч гэдэг; *эсэл нь хэт эсэл эсмэг хоёроос өөр юм.*

ЭСЭЛДЭХ алив бодис хүчилтөрөгчтэй нэгдэх химийн урвал болох.

ЭСЭН сайн, тайван, эрүүл; **эсэн мэнд, энх эсэн, эрүүл эсэн** х о р ш.; **эсэн мэнд** (мэнд сайн, мэнд тайван; *эсэн мэнд явж ирэв).*

ЭСЭРГҮҮ хүний санаа явдал зөв зүйгээс зөрүү буруугий нь; *эсэргүү үзэл суртал; эсэргүү хэрэг явдал.*

ЭСЭРГҮҮЦҮҮЛЭХ эсэргүүцэхийн үйлдүүлэх хэв.

ЭСЭРГҮҮЦЭЛ 1. эсэргүүцэх хүчин, чадал; *дайсны ширүүн эсэргүүцэлтэй тулгарсаар байв; бэрхшээл эсэргүүцлийг даван туулах* 2. аливаа юмыг шууд эсэргүүцсэн илэрхийлэл; *үйлдвэрийн ажилчид цалин хөлс хассаны эсэргүүцэл болгож хорин дөрвөн цагийн ажил хаяв;* 3. аливаа зүйлийг үл зөвшөөрснийг мэдэгдэж гаргах мэдэгдэл; *сонинд эсэргүүцэл нийтлэгдэв;* 4. харилцан нөгөө этгээд; *эсэргүүцэл бөх; эсэргүүцэл дайсан; эсэргүүцэл этгээд.*

ЭСЭРГҮҮЦЭЛДҮҮЛЭХ эсэргүүцэхийн үйлдүүлэх хэв.

ЭСЭРГҮҮЦЭЛДЭХ эсэргүүцэхийн үйлдэлдэх хэв.

ЭСЭРГҮҮЦЭХ 1. эсрэг хариуцах, тэмцэх; *хууль дүрмийг эсэргүүцэх; зүдыг эсэргүүцэх; өвчнийг эсэргүүцэх;* 2. эсэргүүцэл илэрхийлэх.

ЭСЭРГЭН цаг улирлын ирэх хувь; *эсэргэнжил; эсэргэн зун.*

ЭСЭРГЭНЭ зарим өвчний уршгаар хүний биед туурах гөврүү, цэврүү толбо; *эсэргэнэ туурах;* **улаан эсэргэнэ** (хоолой өвдөхийн хамт биед юм туурах нэг зүйл халдварт өвчин, ихэнхдээ хүүхдэд туснa).

ЭСЭРГЭНЭТЭХ эсэргэнэ өвчин тохиолдох.

ЭСЭХ I идээ ундааны зүйл хүчтэй амт орж хувирах; *тараг эсэх; айраг эсэхээр л манайд ирээрэй; гурил эсэхээр талх барина.*

ЭСЭХ II тухайн үйлийн болох буюу эс болохыг асуух өгүүлэхэд хэрэглэх үг; *мэдэх эсэх? болох эсэх? ирэх эсэх? бий эсэх? явах эсэхээ өөрөө мэдээрэй! үүнийг хийх эсэхийг бид мэдэхгүй.*

ЭТГЭР нэгэн этгээд дээш өргүүхэн ээтний нь; *этгэр хоншоортой гутал; этгэр үзүүртэй зүү.*

ЭТГЭЭД 1. тал, зүг; *зүүн этгээд; баруун этгээд; зөв этгээд; буруу этгээд; хоёр этгээдийн хэлэлцээ;* 2. нийлэмжгүй, гажууд, зөрүүд; **этгээд зөрүүд** х о р ш.; *этгээд зантай; этгээд суртал;* **этгээд хэл** (нийт олны хэлнээс ангид цөөн бүлэг хүмүүсийн хоорондоо ойлголцох үг яриа); 3. үл бүтэгчдийг заахад хэрэглэх үг; *зарим этгээд; хорт этгээд; дайсан этгээд; үл бүтэх этгээд; хувьсгалын эсэргүү этгээд; хэрэгтэн этгээд.*

ЭТГЭЭДДЭХ хэтэрхий этгээд болох.

ЭТГЭЭДЛЭХ этгээд зан байдал гаргах; *чи битгий этгээдлээд бай!*

ЭТИЙЛГЭХ этийхэд хүргүүлэх.

ЭТИЙХ этгэр болох.

ЭТРҮҮЛЭХ этрэхийн үйлдүүлэх хэв, ямар нэгэн ажил хэргийг бүтээх, амжуулах.

ЭТРЭХ 1. үйл ажлын бүтэх амжих тийш дөхөмжлөх; 2. юмны нэгэн этгээд дээш өргөгдөх.

ЭТҮҮЛЭХ этэхийн үйлдүүлэх хэв.

ЭТҮҮР өлгөх хамах юм; *хоолны этүүр.*

ЭТЭХ I этүүр хэрэглэн өлгөх хамах; **этэх хамах** х о р ш.; *хоол этэх.*

ЭТЭХ II өдөх, сэдэх.

ЭФИР химийн өнгөгүй, ширгэмтгий, шингэн хачин үнэртэй нэг зүйл нэгдэл, эмнэлэг, техникт хэрэглэнэ; *хухрийн эфир; эфирийн тос.*

ЭХ I 1. өөрийн биеийг төрүүлсэн хатагтай, эмэг эжий, мөн нялх багаас нь онцлогоор асарсан сувилсан хүмүүс; *төрсөн эх; эмэг эх; нагац эх; эхийн ач; эхийн сүү; эхийн санаа урийн төлөө, урийн санаа жаргалын төлөө, эх үрс бүгдээрээ нийлээд, энх тайвныг хамтаар хамгаална* (дуу); **хөхөлт эх** (хөхөө хөхүүлж байсан эх); **хадам эх** (эр эм хоёрын эрийн эх нь эмд, эмийн эх нь эрд хадам болно): **хойт эх** (төрсөн эхийн дараа авсан эцгийн эхнэр); **эцэг эхийн хороо** (сургуулийн хичэээл хүмүүжлийн ажилд туслах зорилгоор сурагчдын эцэг эхээс бүрэлдсэн байгууллага); **эхийн алдар одон** (олон хүүхэд төрүүлсэн эхчүүдэд олгох одон тэмдэг); **эх барих ухаан** (хүний жирэмслэх, төрөх, төрсний дараах үед эмнэлгийн тусламж үзүүлэх тухай ухаан); **эх барьсан эх** (хүүхдийг төрөхөд хүйгий нь салгаж авсан хүн); **эх баригч** (эх барих ухаанд мэрэгжсэн хүн;) **эхий нь эцээхгүй, тугалы нь тураахгүй** (алив үйл явдалд аль алины нь гомдоохгүй, хохироохгүй гэсэн санаа); 2. шилжсэн төрсөн орон нутаг, улс: **эх орон** (а. ямар нэгэн үндэстэн, хүн аймгийн соёл боловсрол, аж амьдралын хувиар шүтэн оршиж хүмүүжсэн буюу улиран уламжилж оршин суусан нутаг газар; *өсөн төрсөн эх орон;* б. аливаа юмны үүсч бий болсон газар нутаг; *Зөвлөлт Холбоот Улс бол социалист хувьсгалын эх орон);* **эх нутаг** (эх орон); **эх оронч үзэл** (эх орон, ард түмэндээ хайртай бөгөөд эх орон, ард түмнийхээ төлөө яахаас ч буцахгүй байх үзэл); **этүгэн эх** (а. газар; б. өссөн төрсөн нутаг); 3. эм мал; *эх малыг өсгөж нэмэгдүүлэх; төллөхөөс нь өмнө эх малыг арчлан тэжээх;* 4. алив юмсын үндсэн үүсэл; **эх хүү** (а. анх хөлсөлсөн зээлдсэн мөнгө, түүний хөлс хүү хоёрыг хавсран нэрлэх нэр; б. бичиг зохиол зураг хөрөг зэргийн юмны анх дууриах үлгэр болгосон зүйл, түүний дууриалган буулгасан хуулсан зүйл хоёрыг хавсран нэрлэх нэр): **эх гаргах** (а. бичиг зохиол зэргийг анх үүсгэн зохиох тогтоох; б. юмыг ёсчлон үйлдэхийн урьд үлгэр дүрэм төлөвлөх; в. зарим нэгэн үйл явдлыг тэргүүлэн үүсгэх); **эх эсгий** (эсгий хийхэд анхны зулхайг зулахад түшиг дэвсгэр болгож дэвссэн эсгий, эсгийний эх ч гэнэ); **эх бичиг** (бичиг зохиолын хамгийн анхны зохиол бичиг); **эх хэмжээ** (юмыг хэмжихэд үндэс болгосон хэмжихүүн); **эх хөрөнгө** (а. агсан уржил, арилжаа худалдаа зэргийг хийхэд үүсгэр болгосон мөнгө юм; б. эсгэх, дарах, ээдүүлэх зэрэг юманд үүсгэр болох үндсэн зүйл; *таргийн хөрөнгө; дарсны хөрөнгө; эсгэх хөрөнгө.*

ЭХ II адаг гэдгийн эсрэг утга, 1. юмны үүсэн гарсан газар; *хэргийн эх; булгийн эх; голын эх;* 2. бичиг зэрэг юмны анхны үүсэл, ноорог, хуулбар бии юм; *судар бичгийн эх; гэрээ бичгийн эх; эх зохиогч; эх данс;* **эх татах** (а. юмыг хийх үйлдэх, зохиох байгуулах зэрэгт өөр зүйлээс дүрэм жишээ болгож дууриан адилтгах; б. үйл ажлыг үйлдэж байгуулан үүсгэх); 3. газрын өндөр этгээд; *жалганы эх; хоолойн эх; хөндийн эх;* 4. юмны тэргүүн, дээд, ахлах этгээд; *суудлын эх жагсаалын эх; сарын эхээр жилийн эхэнд;* **эх адаггүй, эх толгойгүй** (а. хэрэг явдлын будлиантан самуурсны нь; б. ах зах захиргаагүйгий нь); **эх захгүй** (а. дэс дараагүй, хүмүүсийн их багын ёс журамгүйгий нь; б. хэрэг явдлын зэрэг дэс дараатай юмны асар сольцож будлиатсаны нь, эх толгойгүй ч гэнэ); **эх толгойгоо алдах** (эх адаг зэрэг дэс дэвээ алдаж самуурах); **эх сүүлгүй** (үйл хэргийн учир зүй, үүсгэл төгсгөлий нь олоход бэрх болсны нь).

ЭХЛҮҮЛЭХ эхлэхийн үйлдүүлэх хэв, эхлэхэд хүргүүлэх.

ЭХЛЭЛ юмны уг үүсгэл; **эхлэл үүсэл** хорш..

ЭХЛЭЛТ эхлэх үйлийн нэр; *оны эхлэлт дээр; киноны эхлэлт болов.*

ЭХЛЭХ юмны тогтмол үүсэх ба үүсгэх; *хичээл эхлэх; ажил эхлэх; уншиж эхлэх; бичиж эхлэх; хурал эхлэх; дуу эхлэх.*

ЭХНЭР 1. ураг холбосон эмэгтэй; *эхнэр авааүй; эхнэртэй болох;* 2. урьдын цагт нөхөрт холбосон бөгөөд эхнэрийн тэмдэг зүүсний нь.

ЭХНЭРГҮЙ гэргийгүй.

ЭХҮҮДЭЛ 1. зэрлэг хушгын модны дурс навчийг нунтаглан ус хольж голд орхиж загас хордуулах нэг зүйл найруулга; 2. эмийн зүйлийг найруулж усанд орхиж загас эмчлэх найрлага.

ЭХҮҮН зургаан амтны нэг, хэлний эрхтний сэрэхүй мэдрэлд сэрүүн бөгөөд эгдүүцэм хатан амт; *эхүүн цай.*

ЭХЭЛБЭР дуусвар гэдгийн эсрэг утга, 1. өвөлжөө бууцны хуучин ихий нь; *эхэлбэр бууц;* 2. худаг усны элбэг сайн; *эхэлбэр худаг.*

ЭХЭЛЖИРГЭНЭ амьтан богширгын нам, хушуу цайвар, толгой харавтархан, нүд шархан ар улаан, жигүүртээ сэвхтэй, өвөргүй нэгэн зүйл шувуу.

ЭХЭЛМИЙ эхэлбэр.

ЭХЭЛМЭР эрт буюу анх тэргүүнд тугалласан хургалсан үнээ хонь.

ЭХЭР: эхэр татах хүн амьтны амьсгалан ядах мэтээр. ихэд тэвдэж амьсгалыг дотогш хүчтэй дуугаран татах; *эхэр татан уйлах.*

ЭЦЛЭХ үхэх, үгүй болох; *нас эцлэх.*

ЭЦЭГ 1. биеийг үүтгэсэн эрэгтэй хүн; аав; *эцэг эхээ хүндлэх;* **өвөг эцэг** (эцэг эхийн эцэг); **хойт эцэг** (эцгийн дараа эхтэй нь ханилсан хүн); **хадам эцэг** (эр эм хоёрын эрийн эцэг эмд, эмийн эцэг эрд хадам болно); **эцгийн төрөл** (авгууд); 2. амьтныг үүтгэсэн эрий нь; *эцэг мал.*

ЭЦЭГЛҮҮЛЭХ эцэглэхийн үйлдүүлэх хэв.

ЭЦЭГЛЭХ идээ ундааны зүйлийг дээш сацаж, тахил тавиглал болгох; *архи эцэглэх; сүү эцэглэх.*

ЭЦЭЛГЭХ үхүүлэх, мөхөөж дарах, устгах; *нас эцэлгэх.*

ЭЦЭЛТ эцэх үйлийн нэр; **эцэлт цуцалт;** х о р ш.; *эцэлт цуцалтгүй хөдөлмөрлөх.*

ЭЦЭНГЭ эцэнхий, туранхай.

ЭЦЭНГЭР маш туранхилан арьс яс төдий болсон амьтан; *эцэнгэр мал.*

ЭЦЭНХИЙ эцэж турхан болсны нь; **эцэнхий туранхай** х о р ш.; *эцэнхий морь.*

ЭЦЭС адаг, мохоол, сүүл, төгсгөл; *насны эцэс; хэргийн эцэс; хурлын эцэс; улирлын эцэс ;эцсий нь үзэх; эцсий нь харах;* **эцсийн мэдүүлэг** (гэмт хэрэг үйлдэж ял олсон хүний хэргийг таслан шийтгэхийн урьдхан байцаж авах өчиг); эцэс **хойтыг бодох** (хожим, хойчийг бодох): **эцэс болох** (а. дуусах, төгсөх; *энэ ажлыг үүгээр эцэс болгоё;* б. нас барах, үхэх; *нас эцэс болох);* **эцэс болтол** (үхтэл, дуустал); **эцсийн үг** (үхэхийн өмнөх гэрээс үг); **эцсийн үе** (хожмын үе; сүүлчийн үе).

ЭЦЭСГҮЙ сүүл, төгсгөлгүй.

ЭЦЭСЛҮҮЛЭХ эцэслэхийн үйлдүүлэх хэв.

ЭЦЭСЛЭЛ эцэслэх үйлийн нэр.

ЭЦЭСЛЭХ 1. эцэс төгсгөлд хүрэх; *хэрэг эцэслэх; хэл ам эцэслэх;* 2. нас барах, үхэх; *насан эцэслэтэл бидний төлөө, улс олны төлөө байсан юм.*

ЭЦЭСТ сүүлд, төгсгөлд; *эцэст нь хүргэх; эцэстээ сайн муу алин болох нь мэдэгдэхгүй байв.*

ЭЦЭСТЭХ эцэслэх.

ЭЦЭХ 1. амьтны тарга хүч буурч турхан болох; **эцэх турах** х о р ш.; 2. амьтны үйл ажилд алжааж хүчин мохох, цуцах; **эцэх цуцах, эцэх алжаах** х о р ш.; *эцэж цуцахаа мэдэхгүй ажиллаж байв.*

ЭЦЭШГҮЙ эцэх шинжгүй, эцэхийн аргагүй.

ЭЦЭЭХ эцэхэд хүргүүлэх; *унаж явсан морио эцээх.*

ЭЦЭЭХЭН сайны хувь үлэмжтэй, олигтойхон, өөдтэйхөн; *эцээхэн морь эмээллээрэй; би эцээхний нь авах болно.*

ЭЧИХ тэнд одох, очих.

ЭЧНЭЭ нууц далд; *эчнээ бодлого агуулж эцсийн завшааныг горилж байна; алдаж осолдсон бишүү, эчнээ санаагаар үйлдсэн хэрэг;* **эчнээгээр** (нууцгай, далдуур); **эчнээгээр суралцах** (тогтмол хичээл хийхгүй, багшаар тогтмол заалгахгүй суралцах; *аспирантурт эчнээгээр суралцах.*

ЭШ I 1. зэвсэг хэрэгслийн бариул үүсгэр; 2. өвс ургамлын язгуур, гол бие; 3. хэрэг заргын гарал сэдэв; 4. үйл явцлын шалтгаан нөхцөл; **эш хийх** (а. үйл ажилд зохих зүйг баримтлах: б. юманд барнул үүсгэр хийх); **эш ёс** (дагаж явбал зохих зүй); **эш авах, эш олох** (зөвшөөрөл авах); **эш татах** (өгүүлэл зохиолд бусдын ном зохиолоос түшиг дууриал болгон авч мөрдөх, журамлах); **эш үзүүлэх** х у у ч и р с а н (эрт, одоо, ирээдүйн битүү далд үйл ажлыг илэрхийлэн гаргах, өгүүлэх).

ЭШ II гэмших гомдох зэрэгт гаргах аялга; *эш, би юу гэж ингэлээ! эш, би юу гэж явлаа!*

ЭШЕЛОН цуваа; *танкийн эшелон; галт тэрэгний эшелон.*

ЭШЛЭХ 1. сав хэрэгсэлд бариул үүсгэр хийх; *сүх эшлэх;* 2. үйл ажилд зүй журмыг дагаж явах *эшилж аж төрөх.*

ЭШТЭХ өвс тарианы чухам түрүүтэх эш урган гарах; *тариа эштэх; өвс эштэх.*

ЭЭ I 1. болгоомжлуулахын учир урьдаас анхааруулан захихад хэрэглэх аялга; *ээ! алдуузай; ээ! унтчихуузай;* 2. шинэ зүйл сонсоны даруй сонирхон ойшооход хэрэглэх аялга; *ээ, тийм үү? ээ, сайн даа;* 3. юмыг хайрлах өршөөхөд хэрэглэх аялга; *ээ, хөөрхий! ээ, хайран!* 4. бусдыг үл тоомсорлон өгүүлэхэд хэрэглэх аялга; *ээ, тэр яах вэ; ээ, тэр муу юу;* **ээ хээ** (а. юмыг үл тоомсорлоход хэрэглэх аялга; *ээ хээ, тэр яах вэ; ээ хээ энэ барагтай хэрэг;* б: бусдыг доогло, тавлахад хэрэглэх аялга; в. юмыг санасанд хүрэлгүй эв-

дэрсэн гэмтсэн зэрэгт хэрэглэх аялга; *ээ хээ,* энэ чинь эвдрэв; энэ чинь чингэв); **ээ дээ** (а. санаанд явхийтэл нийлэлцсэн зүйлд хэрэглэх аялга; *ээ дээ, мөн зөв; ээ дээ, чухам болно;* б. итгэлгүй юманд болгоомжлохоод хэрэглэнэ; *ээ дээ! мэдэхгүй; ээ дээ!*

ЭЭ II ө-гөөс бусад эм эгшигт үгийн дараагаар орох дуудах сул үг; *ээжээ! худал биз ээ);* **ээ мээгүй** (огт хэлэлцэж чадахгүй хэлгий хүн).

ЭЭВЧ ээвэр, нөмөр сайтай; *ээвч газар.*

ЭЭВЭР нарны илч гялбаа эгцлэн тусах газар; **ээвэр энгэр, ээвэр нөмөр** х о р ш.; *өвлийн хүйтэнд малыг ээвэр газар бичээх нь чухал.*

ЭЭВЭРДҮҮ ээвэр нөмөр бүхий байдалтай.

ЭЭВЭРДЭХ хэтэрхий ээвэр болох.

ЭЭВЭРЛЭХ ээвэр дагах, дагуулах.

ЭЭДИЙ ухаан бодлого гэмтэж аливаа юманд хааш яаш болохы нь: **ээдий буудай болох** (ухаан бодлого гэмтэж хааш яаш болох); **ээдий болох** (нас өтөлж хөдөлж чадахгүй болох буюу ухаан самуурах).

ЭЭДИЙРЭХ 1. будаа зутангийн зэрэг шингэн зүйлийн дээгүүр өрөм тогтох; *цай ээдийрэх;* 2. ээдий болох; *ухаан ээдийрэх.*

ЭЭДМЭГ ээдэм. •

ЭЭДМЭГЛЭХ ээдмэг хийх, ээдмэг болгох.

ЭЭДМЭГРЭХ ээдмэг болох, ээдэм болох.

ЭЭДМЭГТЭХ ээдмэг болон хувирах, ээдмэг тогтох.

ЭЭДМЭГШИХ ээдмэг шинжтэй болох.

ЭЭДРҮҮЛЭХ ээдрэхийн үйлдүүлэх хэв.

ЭЭДРЭХ 1. утас дээс зэргийн самцаж ширэлдэн авд тайлж болохгүйд хүрэх; *утас ээдрэх;* 2. ш и л ж с э н хэрэг явдлын будлиатаж авд таслан шийтгэхүйеэ бэрхтэй болох; *хэрэг нь ээдрэх;* 3. ш и л ж с э н хүний хэл, хэлэлцэхэд будилж чулчрах; *хэл ээдрэх.*

ЭЭДРЭЭ ээдэрсэн нь; *утасны ээдрээ; хэргийн ээдрээ; ээдрээгий нь гаргах; ээдрээтэй талы нь олох.*

ЭЭДРЭЭТЭХ ээдрээтэй болох.

ЭЭДРЭЭХ ээдрэхэд хүрүүлэх, ээдрүүлэх.

ЭЭДҮҮЛЭХ ээдэхийн үйлдүүлэх хэв, ээдэхэд хүрүүлэх; *сүү ээдүүлэх.*

ЭЭДЭМ халуун сүүнд тараг айраг, шар сүү зэрэг эсгэлэн хүчтэй юм хольж ээдүүлснийг буюу түүнээс ялгаран гарах өтгөн идээний хувь; *ээдэм хийх; ээдэм идэх.*

ЭЭДЭН 1. юм наах жонхуу; 2. зутан гэдэг идээ; *гурилын ээдэн; будааны ээдэн.*

ЭЭДЭХ юмны язмагтаж шар устан хувилах; *сүү ээдэх; айраг ээдэх.*

ЭЭЖ эх; *бөөрөнхий биеий нь өсгөсөн ээжийнхээ ачийг яанам бэ хөө* (ардын дуу).

•

ЭЭЗГИЙ сүүг ээдүүлж буцалган ширгээж, нар салхинд тавьж хатаасан нэгэн зүйл идээний нэр; **ааруул ээзгий** х о р ш.; *ээзгий буцалгах; ээзгий ширгээх; ээзгий тавих.*

ЭЭЛ 1. юмны ач тус болох сайны хувь; *тэр бол миний ганц ээл хардаг хүн; энэ морь, над ээл болсон юм;* 2. хор хөнөөл үл болох; *ер нь өвчин гарч байгаа л сураг байх юм, манай үүгээр ч ээл л байна.*

ЭЭЛГЭХ 1. ээхэд хүрүүлэх; 2. ээгдэх.

ЭЭЛЖ 1. халалцах солилцох үйл ажлын зэрэг дараа, хэмжээ хугацаагий нь; **ээлж дараа** х о р ш.; *малын ээлж; манаа дежүүрийн ээлж; ээлжийн ажилтай; хонины ээлж; ээлжийн мастер;* 2. мөнхүү хугацаатай ажилд ажиллах хүмүүс; *өдрийн ээлж ажиллах болов; шөнийн ээлж амрав; ээлжийн манаа.*

ЭЭЛЖИТ ээлж бүхий юм; *ээлжит манаа; ээлжит зорилго; ээлжит хурал.*

ЭЭЛЖЛҮҮЛЭХ ээлжлэхийн үйлдүүлэх хэв, ээлжлэхэд хүрүүлэх.

ЭЭЛЖЛЭЛ ээлжлэх үйлийн нэр.

ЭЭЛЖЛЭХ үйл ажилд тогтоосон ээлж дараагаар ажиллах, халалццагаах; ээлжилж гаргах; *хонинд ээлжлэн явах; манаанд ээлжлэн гарах.*

ЭЭЛЖТЭЙ ээлж бүхий; *өдрийн ээлжтэй; шөнийн ээлжтэй.*

ЭЭЛЛЭХ ээл болох; *аюул хөнөөлтэй юм үл дайран ээллэж өнгөрөв.*

ЭЭЛТ I нарны гэрлийн эгц ээх дулааны чадал; *ээлт сайтай; ээлт муутай.*

ЭЭЛТ II ээл бүхий юм; *ээлт нутаг; ээлт унаа.*

ЭЭЛЭХ хүн амьтны онц аюул хэлмэгдэлд учирч сарних; **ойх ээлэх** х о р ш.

ЭЭМ: ээм халуун маш шарам халуун.

ЭЭМЭГ чихэнд зүүх чимэг, ихэвчлэн үнэт зүйлээр хийнэ, байдал дүрс олон янз; *алтан ээмэг; сувд ээмэг.*

ЭЭНЭГШИЛ ээнэгших үйлийн нэр.

ЭЭНЭГШИХ харилцан дасч ижилдэх.

ЭЭНЭГШҮҮЛЭХ ээнэгшихийн үйлдүүлэх хэв, дасч ижилдүүлэх.

ЭЭП х у у ч и р с а н хааны охинтой ханилсан хүргэн.

ЭЭРМЭГ ээрэм I.

ЭЭРҮҮ үгийг түвшин эгцээр хэлж чадахгүй хүн; *ээрүү хүүхэд.*

ЭЭРҮҮЛ утас томох хэрэгсэл, хэлбэр байдал олон янз; *ээрүүлийн таваг;* **ээрүүл өрөм** (юмыг цоолох нүхлэх багаж).

ЭЭРҮҮЛЭХ 1. ээрэхийн үйлдүүлэх хэв; 2. ээрэгдэх.

ЭЭРЦЭГ I сүүж дунд чөмөг хоёрын нийлэлт уе.

ЭЭРЦЭГ II: **ээрцэг дүүжин** дээрээс дүүжилсэн том хүрдээс зүүсэн дүүжин ооспоос барьж, хүрдийг дагаж эргэн наадах дүүжин.

ЭЭРЭГДЭХ ээрэхийн үйлдэгдэх хэв.

ЭЭРЭЛ горил, хүсэл, горьдол; **ээрэл горил, ээрэл хүсэл** х о р ш..

ЭЭРЭМ I тогоо нэрэхэд буцалсан айраг дээш хөөрч бүрхээрийн дотор этгээдэд наалдаж тогтсон идээ; *ээрэм идэх.*

ЭЭРЭМ II ёжтой, дэгээтэй ярьдаг хүн.

ЭЭРЭМ III эзгүй тал газар; *ээрэм цагаан тал.*

ЭЭРЭМТЭХ ээрэм тогтох.

ЭЭРЭНЦЭГ эргэн харайн наадах нэг зүйл бүжиг; *ээрэнцэг хийх.*

ЭЭРЭНЦЭХ ээрэнцэг бүжиг хийх.

ЭЭРЭХ I ээрүүл машин мэтээр утас ширхэг томох эрчлэх; *утас ээрэх.*

ЭЭРЭХ II 1. хүний хэл ээдрэн хэлэлцэх; *хэл ээрэх;* 2. хүүхэд байн байн уйлах; *манай хүүхэд ээрээд байна.*

ЭЭРЭХ III 1. бусдыг хоргоох, шалгаах; **ээрэх хоргоох** х о р ш.; 2. ш и л ж с э н өвчин авд салахгүй байн байн дахиж тусах; *өвчин ээрэх.*

ЭЭРЭХ IV хүн амьтны хүсч эрэх; *горилон ээрэх.*

ЭЭТГЭР ээтэн, этгэр.

ЭЭТИЙХ ээтэн, ээтгэр болох.

ЭЭТЭН амьтан ба юмны хушуу хамар зэргийн эртгэрхэн; *ээтэн хамартай; ээтэн гутал.*

ЭЭХ юмны илчид юмыг тохиолгон халаах, бүлээтгэх; *наранд ээх; галд гараа ээх.*

Ю

Ю Монголын цагаан толгойн үсэг, хоёр авиаг тэмдэглэнэ, эгшиг гийгүүлэгч хавсарсан үсэг, эгшиг гийгүүлэгч хавсарсан авиа.

ЮАМБҮҮ юмбүү. •

ЮГҮҮРЭЛ югүүрэх үйлийн нэр, нэгшүүрэл.

ЮГҮҮРЭХ б и ч и г хүний нуршин хийгээд идээний зэрэгт нэгшүүрэн дур болих.

ЮД бараг II-ын арван хувийн нэг.

ЮДААГУН х у у ч и р с а н таван эгшгийн нэг, усан махбод эгшиг ч гэдэг.

ЮЛД I илд: **хутга юлд** х о р ш..

ЮЛД II арьсанд гарах загатнах нэг зүйл **өвчин**; *юлд гарах;* **хяргадаг юлд** (арьсанд мөөгөнцөр бижрүү гарч загатнах нэг зүйл юлд).

ЮЛХГЭР тарган цүлцгэр; *юлхгэр гэдэс.*

ЮЛХИЙХ юлхгэр болох.

ЮЛХЭГНЭХ юлхгэр юмны юлхэг юлхэг хөдлөх.

ЮЛХЭЛЗЭХ юлхгэр юмны юлхэс юлхэс хөдлөх.

ЮМ I аливаа байгаа бүх зүйлийг ерөнхийлөн нэрлэх үг; **юм хум** х о р ш.; **идэх юм** (идэх зүйл); **унших юм** (унших ном бичиг); **үзэх юм** (үзэх сонирхох эл зүйлс); **сайн юм** (сайнд тооцогдох зүйлс): **муу юм** (мууд тооцогдох зүйлс); **хайран юм** (харамсвал зохих зүйлс); **юм угаах** (алив зүйлсийг угааж цэвэрлэх); **угаах юм** (угаавал зохих зүйлс); **юмаар юм хийх** (эвдэрсэн хэмхэрсэн, муудсан зүйлээр ашигтай зүйлийг хийх); **юм олох** (*а.* гээгдсэн хаягдсан зүйлийг олох; *б.* худалдаа наймаа, ажил хөдөлмөр хийж өөртөө ашигтай зүйлийг олох); **миний юм** (өөрийн хувьд хамаарагдах эд агуурс): **хүний юм** (бусдад хамаарагдах эд агуурс зэрэг зүйлс); **танай юм** (танд хамаарагдах эд агуурс зэрэг зүйлс); **манай юм** (манд хамаарагдах эд агуурс зэрэг зүйлс); **холын юм** (ойр биш ор-

ших зүйлс); **ойрын юм** (хол биш орших зүйлс); **хөсрийн юм** (хээр байсан зүйлс); **хээрийн юм** (а. хөсрийн юм; б. чоно); **улсын юм** (улс нийтийн өмч хөрөнгө зэрэг зүйлс); **юм үзсэн хүн** (сайн муу олон зүйлийг амьдраддаа үзсэн хүн); **юм үзээгүй амьтан** (амьдраддаа сайн муу алив зүйлийг үзээгүй хүн); **юм мэдэх хүн** (алив зүйлсийг сайн мэдэх хүн); **юм мэдэхгүй хүн** (алив зүйлийг мэдэхгүй хүн); **мэдэх юм** (алив мэдвэл зохих хийгээд мэдсэн зүйлс); **юм болгон** (юм бүхэн); **муу сайн юм** (мууд тооцогдох зүйлс); **юмтай хүн** (хөрөнгө хогшилтой хүн); **юм бодох** (а. зүй зохисыг сэтгэн бодолхийлох; б. бусдад гомдон санах); **юм санах** (бусдад өс хонзон бодож гоморхох); **юм хэлэх** (үг хэлэх); **юм хийх** (ажил үйлдвэр хийх); **юманд тоохгүй** (а. ямар нэгэн юмыг огт үл тоох; б. алив болгоомжлолтой газарт гүжирмэгээр явах); ☆ **сарын юм, сарны юм, биений юм** (эмэгтэйчүүдийн сарын тэмдэг); **газрын юм** (буруу харж гарсан хатиг өвчин). ᠶᠢᠨ᠎ᠠ ᠵᠢᠭ

ЮМ II туслах үйл үг; *би хөдөө явсан юм; би өглөө болгон биений тамир хийдэг юм; төрсөн нутаг чинь хаа юм бэ? энэ бол миний ном юм; чамд яаж хэлэхээр болдог юм бэ?* ᠶᠢᠨ᠎ᠠ

ЮМБУУ өлгий мөнгө, юамбуу ч гэдэг; *тавин лангийн юмбуу.* ᠶᠢᠨᠪᠤᠤ

ЮМГҮЙ 1. юм байхгүй; *хийсэн юмгүй хүн; зүүд зэрэглээ хоёр шиг бариад авах юмгүй, тийм юм байна; сонин юу байна, юмгүй тайван сайхан;* 2. хөрөнгө хогшилгүй ядуу; *юмгүй хоосон хүн.* ᠶᠢᠨ᠎ᠠ ᠵᠢᠭ ᠬᠥᠮᠦᠨ

ЮНГАР юнгэр. ᠶᠦᠩᠭᠡᠷ

ЮНГЭР хичнийн өөр нэр, юнгар ч гэдэг; **юнгэр тахиа** (тахианы нэгэн зүйл); **юнгэр цэгцгий амьтан** (цэгцгий шувууны нэгэн зүйл, бор харагчин ч гэдэг). ᠶᠦᠩᠭᠡᠷ

ЮУ (Н) I хүн төрөлхтнөөс бусад амьтай амигүй бодис, байгалийн үзэгдлийг лавлан асуухад хэрэглэх үг, эр эгшигт үгэнд бичнэ; *энэ юу? тэр юу? сонин юу байна? юу хийж байна? чи юу мэдэх вэ? юу харж үзэж байдаг хүн бэ? юунд тийм байх вэ? чи юунд хэлэв? та нар юунд хоцров? манай энд юугаар ч дутагдах юм алга байна; хөдөө юугаар явах юм бэ? чи юугаар нь яах юм бэ? энэ юуны мах вэ? энэ юуны арьс вэ? юуны төлөө үүнийг хийж байгаа юм?* **юу зовох** (юу ядах); **юу ядах** (хялбархан; *үүнийг хийхэд юу ядах вэ; тийм юм олоход юу ядах);* **юу хийх** (а. лавлан асуух үг; *үүгээр юу хийнэ? үүгээр юу үйлдэнэ?* б. ямар нэгэн юмыг голоход хэрэглэх үг; *үүгээр юу хийнэ вэ? түүгээр юу хийнэ?* **юу хийх вэ** (а. хийх үйл ажлыг заалгахаар лавлан асуухад хэрэглэх үг; *би юу хийх вэ?* б. санаанд үл тохирох үйл юм хийж байгааг үзээд үл тоомсорлож хэлэхэд хэрэглэх үг; *чи үүнийг хийж, юу хийх вэ);* **юу хэлэх вэ** (а. эндсэн цалгардсан газрыг зааж сануулахад хэрэглэх үг; *чамд юу хэлэх вэ;* юу гэх вэ ч гэнэ; б. хэлэх юмгүй; *чамайг яв гэхээс өөр юу хэлэх вэ дээ);* **юу гээ вэ** (дуудсан зэрэгт учрыг лавлан асуух үг; *та юу гээ вэ? чи юу гээ вэ?);* **юу гэнээ** (бусдын хэлсэн үгнийг ухаж мэдээгүйдээ лавлан асуух үг); **юу гэж** (юу гэнэ); **юу юу** (ямар гэсэн санаа; *чи юу юу авчрав? тэнд юу юу байна? тэр юу юу өгүүлэв?);* **юун сайн юм бэ** (яасан сайн юм бэ; *юун сайн юм бэ, одоо хоёулаа явж кино үзээд ирье);* **юун ч их юм бэ** (яасан их юм бэ; *за, юун ч их юм авчирсан юм бэ?);* **юуны тул** (яахын тулд; *юуны тул ажил хийж байна? юуны тул түүнийг хамгаалав?);* **юун хамаа** (хамаагүй); **юун юм** (урьд мэдэхгүй байсан юмыг хожим сонсоход лавлан асуух үг; *юун юм, би мэдэхгүй; юун юм яриад байна);* **юун юунаас чухал** (энэ тэр алив юмнаас онц чухал); **юу юугүй** (одоохон, даруйхан; *юу юугүй явах болов);* **юу ч болов** (эрсэлж шийдсэн зүйлд гаргах үг; *юу ч болов, чингээ; юу ч болов, дүүрсэн хэрэг.* ᠶᠢᠨ᠎ᠠ • ᠶᠢᠨᠪᠠ

ЮУ II урт, хос эгшгээр төгссөн үгэнд хэрэглэдэг, асуух төлөөний үг, эр эгшигт үгэнд бичнэ; *ах чинь яваа юу? энэ олон чинь хоргой юу? чи сургууль дээр очоо юу?* ᠶᠤᠤ

ЮУВАА б и ч и г юм I. ᠶᠢᠨᠪᠠ

ЮУГАА (Н) алив юмыг өөрийнхөө гэж хамаадуулах үг; *гар юугаа; эх орон юугаа хамгаалах.* ᠶᠢᠨᠠ ᠪᠠ • ᠰᠤᠭᠠ

ЮУМ I, эр эгшигт үгэнд бичнэ. ᠶᠢᠨ᠎ᠠ ᠵᠢᠭ

ЮУТАЙ яасан гэх санаагаар гайхах үг; *юутай сайхан өдөр вэ! юутай муухай! юутай сонин; юутай жигтэй!* ᠶᠢᠨᠳᠠᠭ

ЮУХАН: юухан хүүхэн аар саар, жижиг сажиг, энэхэн тэрхэн; *юухан хүүхэн цуглуулж байгаад юм хийх санаатай.* ᠶᠢᠨᠤᠭᠠ

ЮҮ (Н) I юу I, эм эгшигт үгэнд бичнэ. ᠶᠢᠨᠠ

ЮҮ II юу II, эм эгшигт үгэнд бичнэ. ᠶᠤᠤ

ЮҮГЭЭ (Н) юугаа, эм эгшигт үгэнд бичнэ. ᠶᠢᠨᠤᠭᠠ

ЮУДЭН бороо шороонд давхацлан өмсөх малгай; *юудэн малгай.* ᠶᠢᠨᠳᠠᠭ

ЮҮЖ өвс тариа зэргийг хэсэг хэсэг болгож багцлан багласан боодол. ᠶᠤᠰᠤᠨ

ЮУЖЛУУЛЭХ юужлэхийн үйлдүүлэх хэв. ᠶᠢᠨᠠ ᠪᠢᠴᠢᠭᠯᠡᠬᠦ

ЮҮЖЛЭХ юмыг юүж болгох; *өвс юүжлэх.*

ЮҮЛҮҮЛЭХ юүлэхийн үйлдүүлэх хэв, юүлэхэд хүргүүлэх.

ЮҮЛҮҮР юмыг юүлэхэд хэрэглэх хэрэглэл; *шингэн юмыг юүлэх юүлүүр.*

ЮҮЛЭХ 1. нэг савнаас нөгөөд хийж суллах; *ус юүлэх; тогоотой сүүг хувинд юүлэх;* 2. уналга морь малыг сэлэх, солих; *морь юүлэх; улаа юүлэх;* **галав юүлэх** хуучирсан (хамаг юм үгүйболох).

ЮУМ юум, эм эгшиг үгэнд бичнэ.

ЮҮРЭЛ юүрэх үйлийн нэр; *юүрэл тохиолдох.*

ЮҮРҮҮЛЭХ юүрэхийн үйлдүүлэх хэв, юүрэхэд хүргүүлэх.

ЮҮРЭХ яйрах, эвдэрч бутрах; *цонхны шил юүрэх; авдар сав юүрэх; яс юүрэх.*

ЮҮТГҮҮЛЭХ юутгэхийн үйлдүүлэх хэв.

ЮҮТГЭЛ юутгэх үйлийн нэр.

ЮҮТГЭХ юутэхэд хүргүүлэх, сүйтгэх, үрэх, эвдлэх, хэмхлэх; *эд хөрөнгөө юутгэх;* **нас юутгэх, төрөл юутгэх** (үхэх).

ЮҮТЭХ сүйдэх, бүрлэх, барагдах, үрэгдэх, үгүй болох; *хөрөнгө юутэх; усны аюулд юутэх; өвчин тахалд юутэх.*

Я

Я Я үсэг, Я авиа; **Я-гийн төрлийн үсгүүд** (Я, Ё, Е, Ю энэ дөрөв).

ЯА ЯА эмээх, жигших, жигшүүлэхэд хэрэглэх аялга; *яа яа, яасан муухай юм бэ! ай яа яа, айхавтар амьтан байна!*

ЯАЛГАХ хэрхүүлэх; *надаар яалгах гэсэн хүн бэ? яалгах юу байх вэ, танаар ялимгүй ажил хийлгэх гэсэн юм.* •

ЯАЛГУУЛАХ яалгахын үйлдүүлэх хэв. •

ЯАМ (АН) аливаа нэг тухайлсан хэргийг хариуцсан улсын хэмжээний төвлөн захирах захиргааны том газар; *Хөдөө аж ахуйн Яам; Үйлдвэрийн Яам; Соёлын Яам; Гэгээрлийн Яам; Гадаад Яам; Дотоод Яам;* **Элчин сайдын яам** (а. элчин сайд тэргүүтэй дипломат төлөөлөгчийн газар; б. мөнхүү төлөөлөгчийн албан хэрэг явуулах байр; *элчин сайдын яаман дээр очоод ирэв*).

ЯАМАЙ зөвшөөрөхөд хэрэглэх үг, зүгээр, болжээ гэсэн санаа; *чи ажлаа сайн хийсэн нь яамай; хуралдаа хожимдоогүй нь яамай.*

ЯАМГҮЙ: яамгүй сайд эрхэлсэн яамгүй боловч засгийн газрын гишүүн, төрийн сайд.

ЯАМЛАХ I 1. хуучирсан албан хаагчдын ёслох буюу хэрэг шийтгэхээр яамандаа хуралдан суух; 2. хүний их зан гаргаж дэмий төвөгшүүлэх, удаашруулахад хүргүүлэх.

ЯАМЛАХ II хуучирсан ямбалах.

ЯАМЛУУЛАХ яамлахын үйлдүүлэх хэв.

ЯАРАВЧЛАХ аливаа үйл үйлдвэр хийхдээ шамдан чармайж хурдавчлах, түргэвчлэх; *түргэн тусламжийн машиныг яаравчлан явуулах; одоо яаравчлан явахгүй бол нар шингэх нь байна.*

ЯАРАВЧЛУУЛАХ яаравчлахын үйлдүүлэх хэв.

ЯАРАЛГҮЙ 1. яарах хэрэггүй; *яаралгүй яв; яаралгүй ид; яаралгүй ирээрэй;* 2. бусдыг үл тоомсорлон өгүүлэхэд хэрэглэх үг; *тэр юу гэж ярьвал ярьж л байг, яаралгүй хэрэг; ирж л байг, яаралгүй дээ харин.*

ЯАРАЛГҮЙДЭХ хэтэрхий яаралгүй болох.

ЯАРАЛТАЙ яарвал зохилтой, яарал бүхий; *яаралтай ажил; бушуухан дуусгахын төлөө чармайцгаах хэрэгтэй; яаралтай хэрэг.*

ЯАРАМТГАЙ яарамхай.

ЯАРАМХАЙ нэндүү яаруу зантай, яарамтгай.

ЯАРАХ хурдлах, түргэлэх; *ажлаас хожимдоно гэж яарч явна би; энэ ажлыг ажил тарахаас өмнө дуусгах гэж яарч байна; над яарах хэрэг гараад байна; яаран сандран гүйв;* **яарвал даарна** (хэт яарвал алдаа гарна).

ЯАРМАГ бараг бөөнөөр нь зарах, худалдан авахын тулд худалдааны байгууллагуудаас тогтмол зохиох хурал, ярмарк гэж ч бичдэг; *хаврын яармаг оролцох.*

ЯАРУУ хурдан түргэн, тэвдүү: **яаруу давчуу, яаруу сандруу, яаруу тэвдүү** хорш.; *яаруу ажлаар хот руу явах.*

ЯАРУУДАХ хэтэрхий яаруу болох.

ЯАРУУЛАХ яарахын үйлдүүлэх хэв, яарахад хүргүүлэх.

ЯАХ тухайн үйлийг төлөөлөн хэлж болдог үйлийн төлөөний үг, хэрхэх; *үүгээр яах вэ? тэр яах юм бэ? чи яах санаатай байна? чи ирэхгүй яах вэ? миний морь яах вэ; ах хөдөөнөөс ирнэ гэсэн яах вэ? явч болохгүй; явч худал хэлэхгүй хүн; яагаад ийм болов; яагаад тийм олон хоноход ирдэггүй билээ?* **яах вэ** (тоохгүй буюу ээрэл тасарсанд гаргах аялга; *тэр, явахдаа яах вэ, дутагдахгүй; яах вэ, аргагүй чи ав даа);* **яах чинь вэ** (хүний үг явдал зэргийг буруушаан өгүүлэхэд хэрэглэх үг; *чи түүнийг хэлж яах чинь вэ; чи тийм үйл үйлдэж яах чинь вэ);* **яах нь вэ** (хэрхэх нь вэ; *энэ чинь яах нь вэ; тэр яах нь вэ);* **яах билээ** (бэрхшээлтэй үйл явдал тохиолдож хэрхэх аргагүй болж бачимдахад гаргах аялга; *за, одоо яах билээ);* **яах юм бэ** (хэрхэхийг лавлахад хэрэглэх үг); **яах аргагүй** (а. зүйг эрж арга олохгүй бэрхшээх, гайхахад гаргах үг; б. яаж аргалавч үл болохы нь; *хадлангийн ургац ч яах аргагүй муу байна);* **яавал болох** (бэрхшээлтэй үйл явдал тохиолдож ихэд бачимдахад өгүүлэх үг; *яавал болох вэ? яавал сайн бэ?);* **яавал яатугай** (найр тавих буюу тунирхахад хэрэглэх үг; *түүнийг чи яавал яатугай; над хамаагүй, дурааран бол);* **яавал сайн** (учрыг олохгүй зүйлд арга зүйг асууж лавлахад хэрэглэх үг); **яагаа вэ** (юу болоо вэ; *би яагаа вэ, зүгээр л байна; чи үзэгдэхгүй яагаа вэ);* **яагаа ч үгүй** (болоогүй, дуусаагүй; *дуусах цаг яагаа ч үгүй байна; би яагаа ч үгүй байна шүү);* **яадаг юм бэ** (тоомсорлохгүй байгаагаа гаргахад хэрэглэх үг; *тэр намайг яадаг юм бэ; энэ чамайг яадаг юм бэ);* **яадаг билээ** (яах билээ); **яаж ийж** (үйл явдлыг бүтээх гүйцэтгэхэд арай чармайн өнгөрүүлсний нь; *яаж ийж амжуулав).*

ЯАХ ВЭ 1. лавлан асуухад хэрэглэх үг; *ингэж хийвэл яах вэ; чингэж хэлбэл яах вэ;* 2. үйл ажлыг шаардан тулгахад хэрэглэх үг; *чи хийхгүй яах вэ; чи явахгүй яах вэ;* 3. зөвшөөрөхөд хэрэглэх үг; *хийсэн чинь яах вэ; мэдсэн чинь яах вэ.*

ЯАХИН юмны чухам байдал учрыг асуухад хэрэглэх үг, хэрхэн; *яахин тийм хэрэг гарах билээ?* **яахин хэрхэн** (хааш яаш).

ЯАЧИХ юу болов, яав; *яачих нь энэ вэ.*

ЯВ I: **яв тав, яв цав** яг таг тохирч зохицсон нь; *яв тав бэлтгэх; яв цав тохирох;* **яв тав хийх** (хүний үйл ажилд чадамгай болдовсон болох нь; *яв тав хийсэн сүрхий ажилтай хүн).*

ЯВ II хүч нэмэгдүүлэх үг; *яв ягаан.*

ЯВААНДАА энтээшээ, алстаа, хэтдээ; *яваандаа сайжрах биз ээ; яваандаа дадах байлгүй дээ яваандаа сурмаар царайтай.*

ЯВАГ I хуучирсан ялаарь, хүний бие урьдахаас сайжирсны нь.

ЯВАГ II: **яваг шар шувуу** амьтан **янз** шар шувуутай адил болоод бүргэдээс том, ойд оршдог нэгэн зүйл шар шувуу.

ЯВАГДАХ явахын үйлдэгдэх хэв.

ЯВАЙ цог чалх; *явай муутай яданги дорой; явай сайтай сэргэлэн чадамгай.*

ЯВАЙГҮЙ цог чалх, хүнх чавхаагүй, царай муутай.

ЯВАЛДАХ 1. явахын үйлдэлдэх хэв; 2. хурьцал үйлдэх; *сэм явалдах; хүчирхэн явалдах.*

ЯВАЛЦАГЧ явалцсан этгээд.

ЯВАЛЦАХ явахын үйлдэлцэх хэв; *тэдний манай хоёр үргэлж нааш цааш явалцаж байдаг юм; энэ ажилд би явалцах хэрэгтэй; чамтай би явалцъя.*

ЯВАМТГАЙ явахдаа дуртай, их явдаг.

ЯВАМХАЙ явах зантай, явдаг зантай.

ЯВАХ 1. хүн амьтны зорчих; **явах зорчих** хорш.; *буцаж явах; чирч явах; гарч явах; ирж явтал тохиолдов; чамайг явтал хүлээв; багшийг явтал гарч болохгүй; явж байвал явдал бүтнэ, хэлж байвал хэрэг бүтнэ* зүйр; **аянд явах** (алсыг зорьж хээрлэн зорчих); **онгоцоор явах** (онгоцоор зорчих); **мориор явах** (морин уналгаар явах); **усаар явах, усанд явах** (усаар одох); **галт тэргээр явах** (галт тэргэнд сууж зорчих); **газраар явах** (газар замаар зорчих); **агаараар явах (нисэх** онгоцоор зорчих); **хөдөө явах** (хот суурингаас хөдөө гарч одох); **хотоор явах** (хотын дотор сэлгүүцэн одох); **сайн явах** (амьдрал ахуйн талаар боломжтой бүтээмжтэй байх); **муу явах** (амьдрал ахуйн талаар боломж бүтэмж муутай байх); **цуг явах** (хамт явах); **гадаа явах, гадуур явах** (гэр орноос гадагшилж сэлгүүцэн одох); **анд явах** (ан гөрөө хийхээр одох); **өмсөж явах** (хувцас хунарыг биедээ хэрэглэн байх); **барьж явах** (гартаа авч зорчих); **үүрч явах** (ардаа үүрэглэн явах); **аяар явах** (аажим алгуур одох); **зөө-**

лөн явах (аяар явах): **аажим явах** (яаралгүй алгуур удаан одох); **түргэн явах** (маш яарч одох); 2. шатар даам, хөзөр зэргээр нүүх, гарах; *мориороо яваарай; цэцгийн тамгаар явах;* 3. алив үйл явдлыг эрхлэн гүйцэтгэж байх үе; *дарга явах; сайд явахдаа; эрүүл мэнд сайн сайхан явахдаа хийж бүтээсэн юм; чадалтай явахдаа барилдаж байв;* **сургуульд явах** (сургуульд орж суралцах); **ажилд явах** (ямар нэгэн ажил хөдөлмөр эрхлэн гүйцэтгэх); **амьд явах** (үхэхгүй, амьдарч байх); **залуу явах** (хөгшрөөгүй идэр үе).

ЯВГААР унаа уналгагүй, хөлөөрөө; *явгаар явахад дан ч хол газар юм.*

ЯВГАДАХ явган болох, уналга үгүйдэх; *юманд явах гэсэн чинь явгадаад явж чадахгүй л байна*

ЯВГАДУУЛАХ явгадахын үйлдүүлэх хэв.

ЯВГАЛАХ 1. хүн ба шувууны хөлөөрөө явах; *явгалаад явбал хөл даарах нь бага байдаг; элээ явгалж явна;* 2. хүнийг уналга хөлөгнөөс нь салгах; уналга өгөхгүй явган болгох; *элчийн унааг явгалах*

ЯВГАЛУУЛАХ явгалахын үйлдүүлэх хэв.

ЯВГАН хүний унаа, уналгагүйгий нь; *явган хүн; явган улаач; явган цэрэг; явган хүнд даваа арвин, ядуу хүнд ноён арвин* з үй р; **явган суух** (хүний гуя бөгс газарт хүрэхгүй, хөл дээрээ суух); **явган хэрүүл** (ялимгүй хэрүүл); **явган хэл ам** (явган хэрүүл): **явган жагсаал** (уналгагүй жагссан жагсаал); **явган цэрэг** (уналгагүй, хуурай замын цэрэг); **явган зам** (гудамж талбай, төв замын хажуугаар унаагүй хүний явахад зориулан хийсэн зам); **явган ор** (намхан ор); **явган үлгэр** (ардын аман зохиолын нэгэн хэлбэр-урт биш бага хэмжээний үлгэрийн зүйл); **явган шуурга** (цас салхинд хийсч хоёр метрээс доош цас бургин гарах шуурга); **явган салхи** (өндөрт биш салхилах салхи): ☆ **явган өлөн** у р г а м а л (гол дагуу чийгтэй газраар өндөр биш ургах нэгэн зүйл улалж өвс); **явган шарилж** у р г а м а л (хуурайвтар нутгаар ургадаг, хурц үзүүртэй нэг наст өвслөг ургамал).

ЯВГАНАХ 1. хүн амьтан нэг газарт олноор хуралдан цугларч бужигналдан байх; *олон хүн явганаж л харагдана;* 2. хорхой зэрэг олон хөл бүхий амьтны сарвалзан хөдлөх; *хөл нь явганах.*

ЯВГАРАХ уналгатай байсан хүн, явган болох; *уналгагүй явгарах.*

ЯВГАРУУЛАХ явгарахын үйлдүүлэх хэв, явган болоход хүргүүлэх.

ЯВДАЛ явах үйлийн нэр, 1. алив амьтан юмсын хөдөлгөөн, хөдлөл; *нарны явдал; салхины явдал;* 2. морь малын алхдал; *жороо явдал; сайвар явдал; зөөлөн явдлаар явах;* 3. хэрэг, ажил; **ажил явдал, хэрэг явдал** х о р ш.; *бүтэлгүй явдалтай хүн; сайн явдалтай хүүхэд; санхүүгийн явдал; эх орноо хамгаалах явдал гарвал бид хэзээд бэлхэн байх болно; бичиг үсэг үл мэдэх явдал; түүхий эд нийлүүлэх явдлыг хурдан дуусгах хэрэгтэй;* **самуун явдал** (зөв зүйгээс гажуугаар танхайран явахы нь); **явдлаа алдах** (хүний үйл ажил буруудах, муудах); 4. учир; **учир явдал** х о р ш.; *хэрэв ийм явдал дахин гарвал даруйхан мэдэгдэх хэрэгтэй.*

ЯВДАЛТАЙ 1. морь малын тусгай явдал бүхий; *жороо явдалтай морь; сайвар явдалтай морь;* 2. үйл ажлын ажиллагаа төвөг ихтэй; *явдалтай хэрэг байна даа; үүнийг гүйцэтгэхэд нилээд явдалтай байна.*

ЯВИГНАХ хүний ам хурдан, өрсөн ярих буюу эсгүүл байн байн нуршин үглэж ярих; *явигнан хэлэлцэх; явигнасан сүрхий өвгөн байна билээ.*

ЯВЛАГ а м ь т а н бие жижигхэн, хэлбэр байдал шар шувуутай адил нэгэн зүйл шувуу; **явлаг галуу** а м ь т а н (явлагийн адил болоод нүд хонхгор нэг зүйл халуу мэргэн).

ЯВУУ а м ь т а н хав загасны нам, далайд орших нялцгай биет амьтан, урт нь хоёр см. хүрнэ, шаравтар цагаан бүрээстэй, бүрээсийг чимгийн зүйлд хэрэглэнэ, ясы нь ч явуу гэнэ.

ЯВУУЛ: явуулын хүн байран биш, зорчин явах хүн; *явуулын хүнд цай чанаж хоол хийж өгөв.*

ЯВУУЛАГДАХ явуулахын үйлдэгдэх хэв.

ЯВУУЛАГЧ явуулсан этгээд, явуулах үйл гүйцэтгэгч.

ЯВУУЛАХ 1. явахын үйлдүүлэх хэв, одуулах, зорчуулах, илгээх; *томилон явуулах; хөдөө явуулах; сургуульд явуулах; ажил хөдөлмөрт явуулах;* 2. юмыг шилжин хөдлөхөд хүргүүлэх; *захидал явуулах; мэдээ явуулах; утас явуулах; цагаа түлхэж явуулах;* 3. үйл ажлыг гүйцэтгэх; *сонгууль явуулах; ажил хэргээ явуулах; ухууллага явуулах;* 4. хэт хэтрүүлэн ярих; *тэр ч намайг бүр явуулдаг юм.*

ЯВУУЛЛАГА явуулах үйлийн нэр: **ажил звууллага, хэрэг явууллага, арга явууллага** х о р ш.; **явууллага хийх** (а. залилах мэхлэх; б. өөрийн санаа бодлогыг бусдаар дамжуулан хийлгэх).

ЯВУУТ явах замын дашрамд; *чи явуут нөгөө айлаараа буугаад яваарай.*

ЯВХИЙХ юмны таатай тавтай, нийлэмжтэй, тохиромжтой болох; яг хийх ч гэнэ; *явхийтэл тохиров; явхийтэл нийлэлцэв.*

ЯВЦ үйл ажлын явагдах үеийн бүтэмж байдлы нь; *ажлын явц сайн байна; бүтэмж явц дорой байна; ажлыг явц дундуур нь шалгаж байх хэрэгтэй.*

ЯВЦАВ яг таг, явхийтэл; *явцав таарав; явцав тохиолдов.*

ЯВЦАВХИЙХ 1. хүн амьтны явах зорчих, хөдлөх, аашлах, гавшгай ялгум байх; *ажил хөдөлмөрт явцав хийсэн хүн; унахад явцав хийсэн морь;* 2. аливаа хэрэглэгдэхүүний хийц байдал, хэмжээ, үзэмж чанар тавтай нийлэлцэх, тохирох; *явцав хийсэн айл; хийц нь явцав хийсэн элмээл байна.*

ЯВЦГААХ явахын хамтран үйлдэлцэх хэв.

ЯВЦГҮЙ явц муутай, явц нь дорой, урагш муутай, бүтэмжгүй; *хорт ажиллагаа нь явцгүй болох.*

ЯВЦТАЙ явц сайтай, бүтэмжтэй, урагштай; *манай нэгдлийн ажил өөдрөг явцтай байна.*

ЯВЦУУ 1. юмны эн хэмжээ бага; *газар нутаг явцуу; гэр орон явцуу; явцуу хашаа;* 2. юмны зай завсар чухал давч; *явцуу хувцас; явцуу амсар;* 3. ш и л ж с э н санаа бодол гүн биш, хязгаарлагдмал; *ухаан бодол явцуу;* **явцуу үзэл** (хувиа бодсон үзэл).

ЯВЦУУДАХ хэтэрхий явцуу болох; *дээл явцуудаад өмсч болохгүй болжээ; мэдлэгийн хүрээ нь явцуудах.*

ЯВЦУУДУУЛАХ явцуудахын үйлдүүлэх хэв.

ЯВЦУУРАХ 1. явцуу давч болох; 2. өөрийн ашиг сонирхлыг бодох; *хувийн эрх ашгийг бодож явцуурах.*

ЯВЦУУРУУЛАХ явцуурахын үйлдүүлэх хэв.

ЯВЦУУСАХ улам явцуу болох.

ЯВЦУУСГАХ явцуусахад хүргүүлэх.

ЯВЦУУТАХ явцуусах.

ЯВЦУУТГАХ явцуутахад хүргүүлэх, явцуу; болгох.

ЯВШАА 1. санаснаа нуулгүй, шууд хэлэх зантай, явшуур; 2. үглээ, яншаа.

ЯВШИХ 1. санаа явдлаа нууж далдлахгүй илчлэн хэлэх; 2. дэмий ярих, үглэж янших.

ЯВШУУЛАХ явшихын үйлдүүлэх хэв.

ЯВШУУР амны зоргоор явигнаж хэлэлцэх, яншиж үглэх зантай хүн; *явшуур хүн.*

ЯГ I 1. мухардах, тулгарах зэргийн байдал; *яг тулгарах; яг тохиолдох;* **яг мухардах, яг таг мухардах** (юмны учир зүйг олж чадахгүй арга мохох); **яг зогсох** (нэгмөсөн зогсох); **яг мартах** (таг мартах, бүрмөсөн мартах); 2. юмны яв цав, яв тав тохирох байдал; *яг гурван цагт гэж болзов; яг таарах;* **яг таг** (их л тохирох, нийлэлцэх; *яг таг таарах; яг таг нийлэлцэх;* явцав яв тав ч гэдэг).

ЯГ II юмны чанга тусах чимээ гарах; *яг хийтэл мөргөв; яг хийтэл суух; яг яг хийх.*

ЯГАА эмээлийн дөрөө ба гэрийн багананы толгойд гоёж хийсэн хээ угалз, цэцэг зэрэг юм; *багананы ягаа; дөрөөний ягаа.*

ЯГААВТАР арай ягаан, баахан ягаан; *ягаавтар өнгөтэй даавуу.*

ЯГААН цайвгар улаан өнгө; *хуа ягаан; ягаан хүрэн; үзэм ягаан; ягаан хацартай хүүхэд;* ☆ **ягаан цээнэ** у р г а м а л (60—80 см. өндөр ургадаг олон наст өвсөрхөг нэг зүйл цээнэ, ягаан цэцэгтэй, ардын эмнэлэгт шээс чавдагшихад хэрэглэнэ).

ЯГААРАХ юмны өнгө, ягаан туяа татаж харагдах; *ягаарч харагдах өнгөтэй.*

ЯГААРУУЛАХ ягаарахын үйлдүүлэх хэв.

ЯГДАХ мухардах, мохох, туйлдах.

ЯГДУУЛАХ ягдахын үйлдүүлэх хэв.

ЯГЖГАР хүн амьтны бие намхан, жижиг, бахимхны нь; *ягжгар өвгөн; ягжгар хурга.*

ЯГЖИЙХ ягжгар болох; *ягжийсан сүрхий чадалтай морь юм даа.*

ЯГЗАЙХ ягзгар болох, ярзайх, шазайх.

ЯГЗГАР 1. хүн амьтны шүд ярзгар; 2. хүний зан байдал хэдэр хэвцгий нь.

ЯГИА үглээ, яншаа зантай.

ЯГИРАМ 1. аливаа юмны маш хатуу; **агирам ягирам** х о р ш.; 2. нойтон юмны хуурайшиж хатсаны нь.

ЯГИРАХ юмны хатуу буюу маш хуурай болох.

ЯГИХ ягиа болох, үглэх, янших; *үргэлж ягиж байдаг эмгэн шүү.*

ЯГЛУУН аглиун, бат бэх, дөжир.

ЯГНАХ хөгжилтэйгөөр уянгалан эгшиглэх.

ЯГЦ маш чихэж дүүрсний байдал; *ягц чигжүү; ягц чихэлдсэн олон амьтан.*

ЯГЦАТГАХ ягцтахын үйлдүүлэх хэв, улам ягц болгох.

ЯГЦДАХ хэтэрхий ягц болох.

ЯГЦТАХ улмаар ягц болох.

ЯГЧ няг сахлагийн байдал; *ягч ой; ягч ургамал ягч ус.*

ЯГЧДАХ хэтэрхий ягч болох.

ЯГЧТАХ улмаар ягч болох.

ЯГЧИТГАХ ягчтахын үйлдүүлэх хэв, ягч болгох.

ЯГШИХ 1. үйл ажилд огт хэлбэршгүй бат байх; *ягшиж мэдүүлэх; маргаж ягших;* 2. ш и л ж с э н юмыг хөдөлбөргүй болгох; *ягштал боох; ягштал чангал;* 3. их л таарч тохирох; *ягштал тохиров; ягшиж хэлэлцэн тогтов.*

ЯГШУУЛАХ ягшихын үйлдүүлэх хэв.

ЯГШУУР 1. үүд хаалганы хөшүүр мод; *хаалганы ягшуур мод;* 2. ш и л ж с э н ажилсаг, хурдан шаламгай; *ажилд ягшуур хүн.*

ЯДАМ: **ядам хуруу** хүний гарын дөрөвдүгээр хуруу, арнун хуруу ч гэдэг.

ЯДАНГИ 1. хөрөнгө амьдрал дорой, муу; *урьдын цагт яданги амьдарч байв;* 2. бие маш доройтсон нь; *бие нь яданги байгаа бололтой.*

ЯДАНГИР яданги, дорой.

ЯДАНГИРАХ 1. ядуу яданги болох, хөрөнгө чинээ муудах; *хөрөнгөөр яданги рах;* 2. бие маш доройтох; *бие дороитож яданги рах.*

ЯДАНГИРУУЛАХ яданги рахын үйлдүүлэх хэв.

ЯДАТ: **ядат хар** а м ь т а н хэрээтэй адил бөгөөд маш жижигхэн, бараан цохтой, үүрийн хяраагаар дуугарна, том дуутай нэгэн зүйл шувуу.

ЯДАХ 1. үйл ажлаас бэрхшээх халгах; **барьж ядах** (бэрхшээн барьж ажиллаж үл чадах); **халдаж ядах** (ойртож хүрэлцэн чадахгүй бэрхшээх): 2. алив үйлийг үл тэсвэрлэн чадахгүйд хүрэх; *тогтож ядах;* **байж ядах** (тэсч ядан хүлээх); **үзэн ядах** (үзэх дургүй болох, ад шоод үзэх); **биеэ барьж ядах** (тэсвэр хатуужлаа алдах); **тэсч ядах** (сэтгэлээ барьж чадахгүй байх); **хүлээж ядах** (тэсч ядан хүлээх); 3. алив үйлийг арай чарай үйлдсэн болох); **идэж ядах** (дургай дургүй идэх): **хөдөлж ядах** (бэрхшээж арай л хөдлөх); **хийж ядах** (хийсэн хөдөлсөн болох); 4. зүдэх, цөхрөх; *толгой өвдөөд ядаж байна; ядахдаа дулаан хувцас алга; ядахдаа унаа олдохгүй байна; ядахдаа дандаа хождох юм;* **арга ядах** (аргаа барах); **дааж ядах** (даахгүй цөхрөх); **ядаж цөхөх** (ядуугийн учир чармайн зүдэх); 5. түвдэхгүй, хэцүү биш; *тэр ч хийж ядаад байх юм биш; хийж юу ядах вэ?*

ЯДАХГҮЙ 1. ядах юмгүй, хялбар, төвөгдөхгүй; *хийж ядахгүй ажил; сурч ядахгүй зүйл;* 2. болзож болохгүй; *тийм болох ядахгүй; ийм болох ядахгүй; худал болох ядахгүй; би маргааш явж ядахгүй.*

ЯДМАГ 1. дорой, ядруу; *бие ядмагтай амьтан;* 2. ядуу, хоосон; *хоосон ядмаг хүн.*

ЯДРАГАА бие махбодын сулрал, дороитол, ядрал; *мэдрэлийн ядрагаа; ядрагаа багатай.*

ЯДРАЛ ядах үйлийн нэр, дороитол, ядрагаа; *ядрал ихтэй; ядрал бага; насны ядрал ирж байна.*

ЯДРАНГУЙ ядарсан шинж байдалтай болсны нь.

ЯДРАХ 1. зүдэх дороитох: **ядрах зүдрэх, ядрах зутрах, ядрах дороитох** х о р ш.; *ажилдаа ядрах; хөгширч ядрах; өвчинд ядрах;* 2. хөрөнгө чинээ, ахуй амьдралаар хоосрох дороитох, ядуурах; *амьдралаар ядрах; цангаж ядрах.*

ЯДРАШ ядрал, ядрагаа, сулрал дороитол.

ЯДРАШГҮЙ ядрах шинж байдалгүй.

ЯДРУУЛАХ ядрахын үйлдүүлэх хэв.

ЯДУУ 1 хөрөнгө, амьдрал ахуйгаар дутмаг буюу үгэгүү; **ядуу зүдүү, ядуу хоосон, ядуу**

татуу, үгээгүү ядуу х о р ш.; *урьдын цаат ядуу дорой амьдарч байв;* 2. хүчин чадал, мэрэгжил эрдмээр дутуу дорой; **ядуу дутмаг, ядуу дорой** х о р ш.; *өөрийн мэрэгжлээр тун ядуу хүн байгаа юм.*

ЯДУУДАХ хэтэрхий ядуу болох, дутагдах гачигдах.

ЯДУУЛАГ баахан ядуу.

ЯДУУРАЛ ядуурах доройтох үйлийн нэр; *ядуурал тохиолдох; ядуурлын туйлд хүрэх.*

ЯДУУРАХ ядуу болох, доройтох, дордох.

ЯДУУРУУЛАХ ядуурахын үйлдүүлэх хэв.

ЯДУУС ядуу хүмүүс; *өнчин ядуус.*

ЯДУУХАН арай ядуу, баахан ядуу.

ЯЗ хүч нэмэгдүүлэх үг; **яз татах** (юм хумыг татаж язлах; *шуудай гурилыг яз татах);* **яз цохих** (юм хумыг цохиж язлах); **яз үсрэх** (яз болох, язрах); **яз чанах** (мах зэрэг юмыг удбартал чанах, шалз чанах ч гэдэг).

ЯЗАА: хэзээ язааны хэзээний, язгуурын; *хэзээ язааны мэдэнэ; түүнийг би хэзээ язаанаас сайн таних юм.*

ЯЗАВ: язав татав хийх хүн амьтны гар хөл ба уруул ам, мах арьс зэргийн татганан хөдлөх, шазав татав хийх ч гэдэг.

ЯЗАЙХ 1. юмны язгар болж хувирах; 2. ярзайх, шазайх.

ЯЗАЛЗАХ 1. бяцхан юмны үймцэн хөдлөх; *шоргоолж язалзах;* 2. буцалгах юмны буцлахад ойртох; *цай язалзах.*

ЯЗАРХАЙ юмны язарсан газар; *язархай даавуу бүрээс; язархай нэхий.*

ЯЗВАЛЗАХ 1. амьтны уруул ам байн байн язас язас хийх; 2. шингэн юмны зөөлөн буцалж хөдлөх, шазвалзах ч гэдэг.

ЯЗГАНАЛДАХ олон амьтны үймцэн хөдлөх; *талбай дээр язганалдсан олон амьтан юу вэ?*

ЯЗГАНАХ 1. юмны олноор үймэлдэж хөдлөх; *өт хорхой язганах; хүүхэд зулзага язганах;* 2. шазганах; *цай язганаж байна, буцлах нь.*

ЯЗГАНУУЛАХ язганахын үйлдүүлэх хэв.

ЯЗГАР жигдэрсэн зэрэгцсэн төлөв байдлыг заахад хэрэглэх үг; *язгар шүдтэй хүүхэд; язгар ургамалтай газар.*

ЯЗГУУР 1. уг, хэзээний; *энэ хүн язгуураас эндэхийн хүн; язгуурын сайн хүн;* ☆ **үгийн язгуур** (төрөл үгийн үндсэнд байгаа, цаашид задалж үл болох утгат хэсэг); 2. хүний яс угсаа; **язгуур угсаа** х о р ш.; *миний дээд язгуур угсаа бол Боржгин юм;* 3. үүсэл, байгууллаар адил, ойр төстэй ургамал, амьтны нийтлэг ангилал; *малын язгуурын амьтан; шүхэр цэцгийн язгуурын ургамлууд;* 4. алив бодисын эх, төрүүгүү; **язгуур махбод** (бодисын дотор шинжлэх ухааны ямар ч аргаар өөр зүйлийн бодис болгож хувилгах буюу өөр зүйлийн бодисыг нийлүүлэн бүтээж үл болох алт мөнгө, төмрийн зэрэг бодис).

ЯЗГУУРТАЙ язгуур бүхий, үндэстэй, суурвалжтай; *язгууртай айлын хүүхэд.*

ЯЗГУУРТАН феодал ноёдын угсааны хүн; *хан язгууртан; тайж язгууртан.*

ЯЗЛАХ язрахад хүрүүлэх.

ЯЗЛУУЛАХ язлахын үйлдүүлэх хэв.

ЯЗМАГ юмны ээдэн завдаж дотроо хэсэг хэсэг бөөн тогтон үүсэнний нь; *сүүний язмаг; шөлний язмаг;* **язмаг урсах** (нүдний нулимс нуух хамт урсан гарах); **язмаг суух** (язмагтах).

ЯЗМАГРАХ язмаг болох.

ЯЗМАГТАХ язмагтай болох; *сүү язмагтах.*

ЯЗМАГТУУЛАХ язмагтахын үйлдүүлэх хэв.

ЯЗМАГШИХ язмаг шинжтэй болох.

ЯЗРАХ зөөлөн чанарын юмны хэгэрэх, шалбарах, сиймийх, цоорох; *зэрийн даавуу бүрээс язрах; арьс язрах; үүл язрах.*

ЯЗРУУ язмаг.

ЯЗРУУТАХ язмагтах, язруу тогтох.

ЯЙ талбайн хэмжүүр, тариалангийн газрын зуун үрийн газар.

ЯЙВАЛЗАХ яйвгар юмны яйвас яйвас хөдлөх.

ЯЙВГАНАХ яйвгар юмны яйвга яйвга хөдлөх.

ЯЙВГАНУУЛАХ яйвганахын үйлдүүлэх хэв.

ЯЙВГАР 1. амьтны эрүү урт, урагшаа түрэнгий нь; *яйвгар эрүүтэй;* 2. яйжгар; *яйвгар араг; яйвгар гэр.*

ЯЙВИЙЛГАХ яйвихийн үйлдүүлэх хэв.

ЯЙВИЙХ яйвгар болох.

ЯЙЖГАНАХ яйжгар юмны яйжиг яйжиг хөдлөх.

ЯЙЖГАНУУЛАХ яйжганахын үйлдүүлэх хэв.

ЯЙЖГАР юмны элэгдэж эвдэрч зохих хэв байдал нь яйвийж жайвийж хувирсны нь; *яйжгар тэрэг; яйжгар арāг; яйжгар саравч.*

ЯЙЖИЛЗАХ яйжгар юмны яйжис яйжис хөдлөх.

ЯЙРАХ эвдрэх хэмхрэх, бутрах, үүрэх; **яйрах хэмхрэх, яйрах бутрах, үүрэх яйрах** х о р ш.; *яйрч унах; цонхны шил яйрах.*

ЯЙШИН машин, тэрэгний дугуйн голыг аралтай нь бэхлэх хэрэглэл; *тэрэгний яйшин.*

ЯЛ улсын цааз хууль, олон нийтийн хэв журмыг зөрчиж гэм буруу болсон үйл явдал, түүнд ноогдуулсан шийтгэл зэмлэл; **ял шийтгэл, ял торгууль, ял төлбөр, ял зэмлэл, ял янх** х о р ш.; *торгох ял; хорих ял; алах ял;* **ял хийх** (а. хууль цаазад эрсдэх гэмт хэрэг гаргах; б. гэмт хэрэг үйлдэгсдэд шийтгэл ногдуулах): **ялын төлөвлөгөө** (гэмт хэрэг үйлдсэн хүнд уг хэргийн хүнд хөнгөнийг үзэж зохих шийтгэл зэмлэлийг ногдуулсан төсөл); **ял унагаах, ял ноогдуулах** (гэмт хэрэг үйлдсэн хүнд зохих шийтгэлийг ногдуулан тогтоох); **ял хүлээх** (үйлдсэн хэргийг биедээ дааж авах ба гэмт хэргээ илчлэн гаргах); **ял тулгах** (үйлдсэн гэмт явдлыг тулган хүлээлгэх); **ял шийтгэх** (шийтгэл ногдуулан хүлээлгэх); **ял торгох** (гэмт хэрэг үйлдэгсдэд мөнгөн шийтгэл ногдуулах); **ял эдлүүлэх** (ногдуулсан шийтгэлийг эдлүүлэх): **ял хэлтрүүлэх** (ногдсон шийтгэлийг өршөөж уучлах).

ЯЛАА (Н) хос далавчит шавьжуудын нийт нэр, төрөл зүйл маш олон; **ялаа шумуул, ялаа батгана** х о р ш.; **ялааны үлдүүр** (ялаа хөөх хялгас үсээр хийсэн ширвүүл); **ялаа баригч** а м ь т а н (болжморын язгуурын нэг зүйл шувуу, шавьж иддэг учраас ашигтай шувуу); **ялааны хор** у р г а м а л (а. улаан малгайтай нэг зүйл хорт мөөг, үүгээр ялаа хордуулах хор хийнэ; б. ялаа хордуулж устгах хор).

ЯЛААРЬ 1. өвчтэй хүний бие эдгэрч засрахы нь; *өвчин ялаарь болж байна;* 2. аливаа юмны амар хялбары нь; *ялаарь ажил; ялаарь хэрэг.*

ЯЛААРЖИХ ялаарь болох, өвчин эдгэрч сайжрах.

ЯЛААРШИХ өвчний эдгэж завдах, наашлах төлөв орох.

ЯЛААХ нялзаах, нимгэн тараах.

ЯЛАГДАЛ ялагдах үйлийн нэр, дийлдэл, автагдал.

ЯЛАГДАХ ялахын үйлдэгдэх хэв, автагдах, дийлэгдэх.

ЯЛАГДАШГҮЙ дийлдэшгүй, давагдашгүй.

ЯЛАГЧ ялсан этгээд; *ялагч тал нь.*

ЯЛАЛГАЛЗАХ үйл ажилд аядан нийлүүлж явах.

ЯЛАЛТ ялсан нь, дийлэлт; *ялалтаас ялалтад хүрэх; хувьсгалын ялалт; ялалтын баяр.*

ЯЛАМ: ялам мод у р г а м а л навчаар нь хүр хорхой тэжээдэг, үрийг иддэг нэгэн зүйл мод.

ЯЛАМГАЙ 1. санаа зөөлөн, явдал түвшин шударгы нь; 2. хүний сэтгэл хэлбэлзэн тогтвор муутайгий нь.

ЯЛАМГАЙЛАХ яламгай зан байдал гаргах,

ЯЛАМГАЛЗАХ 1. сэтгэл чандгүй, зөөлдөн пяцалхийлах; 2. зусар зан байдал гаргаж долдойлох.

ЯЛАНГУЯА аливаа юмны дотроос зарим зүйлийг онц болгож заахад хэрэглэх үг; *манай мал сүргийн дотроос ялангуяа үхэр ашиг шим ихтэй; нэн ялангуяа одоо үед...*

ЯЛАХ I дийлэх, давах; **ялах дийлэх, ялах давах** х о р ш.; *Зөвлөлт Холбоот Улс бол ялсан социализмын орон мөн.*

ЯЛАХ II нялах; *шавар ялах; тос ялах.*

ЯЛБАГАР нялцгар, улцгар юм.

ЯЛБАЙХ нялцайх улцайх, ялбагар болох.

ЯЛГАА 1. ялгал, ялгавар бүхий; *ялгаа нь юу вэ? ялгаагий нь гаргах хэрэгтэй;* 2. юмыг төрөл ангиар ялгаварлаж нарийн тодорхой хийсэн ялгал; *тооцоо бодохдоо урьдчилан ялгаа хийвэл сайн байдаг.*

ЯЛГААГҮЙ ялгалгүй, ялгаваргүй, адилхан байдалтай; *хөдөө явсан хотод суусан хоёр над ялгаагүй.*

ЯЛГААТАЙ ялгаа бүхий, ялгавартай, өөр байдалтай.

ЯЛГАВАР 1. аливаа юмны салган ялгаж болох бэлэг тэмдэг, учир шалтгаан; *овог удмын ялгавар; гарал төрлийн ялгавар; өнгө зүсмийн ялгавар; үзэл онолын ялгавар; өвөл зуны ялгавар;* 2. ялгагдсаны нь.

ЯЛГАВАРГҮЙ 1. авах гээх, сонгох шаарлахын танигдалгүй юм; 2. зарим нэгэн үг байдал өөр боловч адил боловч утга чанар нэгэн адил зүйл.

ЯЛГАВАРЛАГДАХ ялгаварлахын үйлдэгдэх хэв.

ЯЛГАВАРЛАХ 1. юмыг ангилах, салгах, ялгах, тодорхойлох; *сайн муугаар ялгаварлах; адил өөрөөр ялгаварлах; их багаар ялгаварлах; үйл ажлаар ялгаварлах;* 2. бусдыг ялгавартай үзэх; *бусдыг илүү ялгаварлан үзээд байх юм.*

ЯЛГАВАРЛУУЛАХ 1. ялгаварлахын үйлдүүлэх хэв; 2. ялгаварлагдах.

ЯЛГАГДАХ ялгахын үйлдэгдэх хэв.

ЯЛГАГЧ 1. ялгах үйлийг гүйцэтгэгч юм; *архивын материалыг ялгагч; үр тариа ялгагч машин; ноос ялгагч;* 2. хуучирсан албан хэрэг шийтгэгч хүн; *ялгагч түшмэл; хэрэг ялгагч.*

ЯЛГАЙ хэл дэвсэн хэлэлцэх зантай хүн.

ЯЛГАЛ 1. ялгах үйлийн нэр; **ангилал ялгал** хорш.; 2. юмны тусгаарлан салгаж болох тэмдгий нь; *төрөл ялгал олон болно;* **тийн ялгал** (өгүүлбэр дахь үгийн утгаас шалтгаалан нэр үг, үйлт нэр зэргийг хувилгах хэлбэр).

ЯЛГАЛГА 1. зөв бурууг тайлан гаргасан үг, бичиг зохиол; 2. юмыг сайн муу зэрэг дэсээр ялгах ажиллагаа.

ЯЛГАЛГҮЙ ялгаваргүй, ялгаагүй, адилхан.

ЯЛГАЛЛАХ 1. байн байн ялгах, олныг ялгах; 2. тийн ялгалын дагавар залгаж үгийг хувилгах; *тийн ялгалаар ялгаллах.*

ЯЛГАМЖ ялгавар, ялгагдах зүйл нь.

ЯЛГАМЖАА ялгамжтай зүйл нь.

ЯЛГАМЖЛАХ ялгамжтай болгох.

ЯЛГАРАХ 1. хольсон нийлэлцсэн юмны өөрсдөө буюу бусдын хүчээр анги анги болох; *хонь ямаа ялгарах; хурга ишиг ялгарах;* 2. юмны үнэн худал, сайн муу, зөв буруу мэтийн ялгавар илрэх; *үнэн зөв нь ялгарах.*

ЯЛГАРУУЛАХ ялгарахын үйлдүүлэх хэв, ялгарахад хүргүүлэх.

ЯЛГАХ ялгаварлах, ангилах, тусгаарлах; *хар цагааныг ялгах; үр ялгах; хурга ялгах; мал ялгах; ай айгаар нь ялгах; алаг үзэж ялгах.*

ЯЛГУУЛАХ 1. ялгахын үйлдүүлэх хэв; 2. ялгагдах.

ЯЛГУУМ 1. хүний зан ааль элдэг, шударга, хөдлөх аашлах байдал хөнгөн тавшгайгий нь; **ялгуум шулгуум** хорш.; *ялгуум зантай хүн;* 2. морь малын унах эдлэхэд хөнгөн зохистойгий нь; *ялгуум зөөлөн явдалтай морь;* 3. идэх уух юмны тааламжтай илбэрүүгий нь; *ялгуум сайхан идээ; идэхэд ялгуум хоол.*

ЯЛГУУМХАН 1. баахан ялгуум; 2. ялгуум нь бахдамаары нь.

ЯЛГУУСАН бүрмөсөн дийлсэн, нэгэнт дийлсэн нь; *ялгуусан хувьсгал; ялгуусан арми; ялгуусан хэнгэрэг дэлдэх.*

ЯЛГУУХ бүрмөсөн дийлэх, ялах, нэгмөсөн дийлэх.

ЯЛГҮЙ холбогдолгүй, гэм хориггүй.

ЯЛДАМ 1. аянтал, дашрам, далим; *ажлын ялдмаар гүйцэтгэх ажил;* 2. морь малын ам хамар зөөлөн ялгуум; *ялдам аятай унаа;* 3. нийлэмжтэй, эетэй; *ялдам зантай хүүхэд.*

ЯЛДАМЛАХ 1. ялдмаар болох, аянтлаар болох; 2. ялдам зан байдал гаргах.

ЯЛДАМХАН баахан ялдам, нилээд ялдам, нийлэмжтэй, аятайхан зан байдалтай; *ялдамхан хүн байна билээ.*

ЯЛДАР дашрамд, далимд; *ялдар сонсгох нь; ялдар амрыг эрж ёсолсон...*

ЯЛЗ шалз; *ялз чанах.*

ЯЛЗАРХАЙ ялзарсан юм; *гутаж ялзархай болсон зүйл байна.*

ЯЛЗЛААХ ялзлуулах, ялзруулах.

ЯЛЗЛАХ ялзрахад хүргүүлэх, ялзруулах.

ЯЛЗЛУУЛАХ ялзлахын үйлдүүлэх хэв.

ЯЛЗМАГ ялзарч гүйцсэн юм; *ялзмаг хөрс; ойн ялзмаг; бууцны ялзмаг.*

ЯЛЗМАГДАХ хэтэрхий ялзмаг болох.

ЯЛЗМАГЛАХ ялзмаг болгох.

ЯЛЗМАГРАХ ялзмаг болох.

ЯЛЗМАГТАХ ялзмагтай болох, ялзмаг тогтох.

ЯЛЗМАГШИХ ялзмаг шинжтэй болох, ялзрах шинж орох.

ЯЛЗРААХ ялзрахад хүргүүлэх, ялзруулах.

ЯЛЗРАХ 1. юмны халуун юманд шалзрах, нялтрах: **ялзрах шалзрах** х о р ш.; *ялзартал буцалгах;* 2. юмны өгөршиж өмхрөх, илжрэх, тамтрах; *мод ялзрах; эсгий ялзрах; даавуу ялзрах;* 3. ш и л ж с э н хүний үхширсэн үйл ажлаа баримтлан зууралдах; *үзэл санаагаар ялзрах; үйл ажлаар ялзрах.*

ЯЛЗРАЛ ялзрах үйлийн нэр.

ЯЛЗРУУЛАХ ялзрахын үйлдүүлэх хэв, ялзрахад хүргүүлэх.

ЯЛИАГҮЙ шалигүй, үл ялих; *ялиагүй юмнаас шалиагүй хэрэг гарав гэгчээр...*

ЯЛИАТАЙ бага сага, хэрэгтэй хэрэггүй, аар саар, их юм биш; *өгсөн зүйл нь ялиатай ч юм биш байна билээ; тийм ялиатай ялиагүй юм хэрэггүй.*

ЯЛИГҮЙ ялихгүй, ялиагүй; *ялигүй зан хүнд хэрэг байдаггүй юм.* • **ЯЛИМГҮЙ** ялихгүй, аар саар юм; *ялимгүй юмнаас болж хүнтэй хэрэлдэх; ялимгүй зүйлээр хөөцөлдөж цагийг барах.*

ЯЛИН 1. дандаа, ямагт; *ялин тийм зантай хүн; ялин үл бүтэх ажил хийж байдаг юм;* 2. нэгэн адил; *ялин тэр; ялин энэ.*

ЯЛИХГҮЙ бага сага, аар саар, шалихгүй; *ялихгүй хэрэг; ялихгүй юм.*

ЯЛЛАГДАХ яллахын үйлдэгдэх хэв.

ЯЛЛАГЧ ялт хүнд түүний уг хийсэн хэргийн учир холбогдлыг уудлан гаргаж ногдвол зохих ялыг зааж тулгах хүн; *улсын яллагч; олон нийтийн яллагч.*

ЯЛЛАХ ял ногдуулах, ял шийтгэх.

ЯЛЛУУЛАХ яллахын үйлдүүлэх хэв.

ЯЛМА арьсны нэг зүйл халдварт өвчин.

ЯЛМАТАХ ялма өвчин тусах.

ЯЛТ ял ногдсон хүн; *ялт этгээд; ялт хэрэг.*

ЯЛТАЙ ял ногдом үйл хэрэг хийсэн хүн, ял шийтгэгдсэн хүн; *ялтай хэрэг үйлдсэн хүн.*

ЯЛТАЙХ ялтгар болох.

ЯЛТАН I хэрэгтэн хүн, ялтай хүн; **ялтан хэрэггэн; ялтан гэмтэн** х о р ш.; *ялтны ширээнд суух.*

ЯЛТАН II ялтгар хэлбэр байдалтай юм; *ялтан таваг; ялтан шанага.*

ЯЛТАНДАХ хэтэрхий ялтгар ялтан болох.

ЯЛТАС алив юмнаас унасан ховхорсон, хэлтэрсэн нимгэн хэсэг; *чулууны ялтас.*

ЯЛТАСРАХ ялтас болох.

ЯЛТГАР сав суулгын ёроол, ам амсар гүнзгий хонхор биш байдалтайгий нь; *ялтгар таваг; ялтгар түмпэн; ялтгар шанага.*

ЯЛТРАХ өчүүхэн шалбарах, хэлтрэх, холтрох хэзрэх; *арьс нь ялтрах; будаг нь ялтрах.*

ЯЛТРУУЛАХ ялтрахын үйлдүүлэх хэв.

ЯЛУУ 1. тэрэгний арал шатны гуяны хооронд холбосон хөндөл мод; *тэрэгний ялуу;* 2. цонх үүд зэргийн юмны бяцхан хөндлөн мод; *цонхны ялуу; хаалганы ялуу.*

ЯЛУУЛАХ 1. ялахын үйлдүүлэх хэв; 2. ялагдах.

ЯЛХАЙХ ялхгар болох, ялхайж харагдах, улхайх.

ЯЛХАЛЗАХ ялхгар юмны ялхас ялхас хийх.

ЯЛХГАНАХ ялхгар юмны ялхга ялхга хөдлөх.

ЯЛХГАР 1. амьтны бие махбод махлаг булхгар; *ялхгар тарган хүн; ялхгар том гахай;* 2. нялцгар шингэн байдалтай юм; *ялхгар шавар; ялхгар нус.*

ЯЛЦАЙХ ялцгар болох, нялцайх.

ЯЛЦГАЙ нялцгай, юмны байдал шингэн бөгөөд наалдангихны нь; *ялцгай шавар; ялцгай гурил.*

ЯМ адуу зэрэг битүү туурайтан амьтанд тусах нэг зүйл халдварт өвчин.

ЯМАА (Н) ус урт, сүүл бага, ац туурайтай, хивэгч, хөхөөр өсөх амьтан, зэрлэг тэжээвэр хоёр зүйл бий; *ямаа туйлавч янгирцаг эвдэх-*

гүй; **ямаан үс** (амьтны үс ямааны үстэй адил төстэйгий нь; *ямаан үстэй хонь);* **ямааны мах халуун дээрээ** (алив үйлийг хийвэл даруйхан, шинэ сэрэг дээрээ гэсэн санаа); **ямаан хилэн** (нэгэн зүйл бараа, хөвөнгөөр өнгө этгээдэд тачир бөгөөд нягт үс гаргаж нэхсэн бөс); **ямаан эвэр** у р г а м а л (балчиг газар бут бутаар ургадаг, навч нь туйлантай адил нэг зүйл ургамал); **ямаан бор** у р г а м а л (дурс хар, дүгрэг навчтай, мах улаан болоод артай нэгэн зүйл мод); **ямаан арц** у р г а м а л (арцны нам, навчны үзүүрт өргөстэй нэгэн зүйл арц); **ямаан шарилж** у р г а м а л (хуучин үндэснээс ургахгүй, үрээс малтуушлан ургадаг нэгэн зүйл шарилж): **ямаан бургас** у р г а м а л (ойд ургана, навч нь энгийн бургастай адил, дурсны уг этгээд хөхөвгөр, үзүүр этгээд нь улаавтар нэгэн зүйлийн бургас); **ямаан харгана** у р г а м а л (тал хээрийн бүсэнд намхан ургадаг, тод шар өнгийн хальстай нэг зүйл харгана); **ямаан гөрөөс** (янгир); **ямаан бүрээ** (далайн нэгэн зүйл амьтны яс, дотроо хөндий, гадна тал нь арзгар, үлээвэл орхирч дуугарна); **ямаан ууц** (хилэнцэт хорхой). ᠶᠠᠮᠠᠨ ᠦᠰᠦ

ЯМААЖИХ ямаагүй буюу цөөн ямаатай хүн, ямаатай буюу олон ямаагай болох. ᠶᠠᠮᠠᠵᠢᠬᠤ

ЯМААЖУУЛАХ ямаажихын үйлдүүлэх хэв. ᠶᠠᠮᠠᠵᠢᠭᠤᠯᠬᠤ

ЯМААЛАГ I 1. ямааараг; 2. ямаа олонтой. ᠶᠠᠮᠠᠯᠠᠭ

ЯМААЛАГ II а м ь т а н элжигтэй адилхан болоод морины сүүл мэт сүүлтэй, эвэр дүгрэгхэн урт нэг зүйл амьтан.

ЯМААРАГ хүний ялиагүй өвчин зовлон зэрэгт хүлцэл тэсвэргүй янгуучий нь. ᠶᠠᠮᠠᠷᠠᠭ

ЯМААРАХ ямааараг зан байдал гаргах. ᠶᠠᠮᠠᠷᠠᠬᠤ

ЯМААРХАГ ямааараг. ᠶᠠᠮᠠᠷᠬᠠᠭ

ЯМААРХАХ ямааараг зан байдал гаргах. ᠶᠠᠮᠠᠷᠬᠠᠬᠤ

ЯМААРХУУ 1. ямаархаг; 2. ямаатай төстэй; *ямаархуу амьтан байна билээ.* ᠶᠠᠮᠠᠷᠬᠤ

ЯМААТАХ юмны хөө шатах; *тогоо ямаатах; зуух ямаатах.* ᠶᠠᠮᠠᠲᠠᠬᠤ

ЯМААТУУЛАХ ямаатахын үйлдүүлэх хэв. ᠶᠠᠮᠠᠲᠤᠯᠬᠤ

ЯМААХАЙ у р г а м а л гол төлөв өтөг бууц, тариалангийн газар зэрэгт ургана, моголцогхон үндэстэй, чанаж шарж иддэг нэгэн зүйл ургамал. ᠶᠠᠮᠠᠬᠠᠢ

ЯМАГТ ургэлжид, хэзээд; *чи ямагт завшив; амьтан, ямагт амьдралын төлөө тэмцэнэ; цаг ямагт чингэж байхын хэрэг юу байна?* ᠶᠠᠮᠠᠭᠲ

ЯМАР 1. аливаа хүн, юмны чанар байдал, овор дүр өнгө тэмдэг зэргийг лавлан асуухад хэрэглэх асуух төлөөний үг; *ямар чанартай эд вэ? ямар байдалтай юм бэ? ямар ялгавартай байна? ямар утга агуулгатай зүйл бэ? ямар санаатай хүн бэ; ямар ямар улс байна вэ?* **ямар ч** (юу ч, яасан ч; *ямар ч бараа харагдахгүй байна; ямар ч тус болохгүй байна; ямар ч байсан би мал маллана);* 2. сэтгэл хөдөлсөнд хэрэглэх үг, яасан; *ямар сайн юм бэ! ямар хачин юм бэ! ямар сайхан агаар вэ! ямар сайхан зун бэ!* **ямар нэгэн** (алив нэгэн *ямар нэгэн тодорхой ажил хийх ёстой; ямар нэгэн хүнтэй уулзах хэрэгтэй).* ᠶᠠᠮᠠᠷ • ᠶᠠᠮᠠᠷᠪᠠ

ЯМАРВАА алив, аливаа; *ямарваа нэг ажил тохиолдвол даруй мэдэгдэх хэрэгтэй.* ᠶᠠᠮᠠᠷᠪᠠ • ᠶᠠᠮᠠᠷᠪᠠᠨ

ЯМАРХАН мартсан, эргэлзсэн үйл ажлыг санагалзан эрж хэлэлцэхэд хэрэглэх үг; *ямархан юм билээ? ямархан хэрэг болж байна? чухам ямархан ном байлаа?* ᠶᠠᠮᠠᠷᠬᠠᠨ

ЯМБА 1. хүнд олгогдсон онцгой эрх; **эрх ямба** х о р ш.; *эрх ямбаа эдлэх;* 2. ш и л ж с э н биеэ тэвхэрлэн хайрлаж байгаагий нь. ᠶᠠᠮᠪᠠ • ᠶᠠᠮᠪᠠ

ЯМБАЛАХ 1. эрх ямбыг эрхэмлэх; 2. ш и л ж с э н хүний биеэ хэтэрхий тэвхэрлэх, ямбаа эдлэх. ᠶᠠᠮᠪᠠᠯᠠᠬᠤ • ᠶᠠᠮᠪᠠᠯᠠᠬᠤ

ЯМБАЛУУЛАХ ямбалахын үйлдүүлэх хэв. ᠶᠠᠮᠪᠠᠯᠠᠭᠤᠯᠬᠤ • ᠶᠠᠮᠪᠠᠯᠠᠭᠤᠯᠬᠤ

ЯМБАТАЙ ямба бүхий этгээд. ᠶᠠᠮᠪᠠ ᠲᠠᠢ • ᠶᠠᠮᠪᠠ ᠲᠠᠢ

ЯМБАТАН эрх ямба бүхий хүмүүс. ᠶᠠᠮᠪᠠᠲᠠᠨ ᠶᠠᠮᠪᠠᠲᠠᠨ

ЯМБИГАР ямбий болсон юм; *ямбигар төрэг.* ᠶᠠᠮᠪᠢᠭᠠᠷ

ЯМБИЙ эвдэрч муудсаныг буюу царай үзэмж, яс чанар маш муу болсон юм; *ямбий гэр; ямбий төрэг.* ᠶᠠᠮᠪᠢ

ЯМБИЙЛГАХ ямбийхын үйлдүүлэх хэв. ᠶᠠᠮᠪᠢᠯᠭᠠᠬᠤ

ЯМБИЙХ ямбигар болох. ᠶᠠᠮᠪᠢᠬᠤ

ЯМБУУ хөвөн нэхмэл бүдүүлэг даавуу барааны нийт нэр, зүйл олон; *цагаан ямбуу.* ᠶᠠᠮᠪᠤ

ЯМПИЙ: ямпий шаазан маш бүдүүлэг хийцтэй ваар шаазан. ᠶᠠᠮᠫᠢ

ЯМТАЙ I 1. ямбатай; 2. х у у ч и р с а н хүний тунирхуу зангайгий нь. ᠶᠠᠮᠲᠠᠢ

ЯМТАЙ II ям өвчин бүхий.

ЯМТАН ямбатан.

ЯМХ хэмжүүрийн нэр, нэгэн хос алдыг зуу хуваасны нэг, цун ч гэнэ; нэг ямх нь 32 мм. болно.

ЯН I хоолойгоор хөг оруулж уянгалан эгшиглэх ая; **ян ин** (ялаа батгана зэрэг амьтны нисэхэд дуугарах дуу); **ян ин хийх** (а. хүний үргэлж үглэн янших: б. нохойн үргэлж хуцах; в. чихэнд хангинам дуу чимээ хадан сонсдох).

ЯН II энгийн нүдэнд үл үзэгдэх маш жижиг эгэл организм; **ян судлал** (ян судлах ухаан); **ян судлалч** (ян судлах мэрэгжилтэн).

ЯН III: **ян даавуу** хөвөнгөөр нэхэж хийсэн маш нимгэн няг зөөлөн бөс бараа.

ЯНАГ 1. амраг; **янаг амраг** х о р ш.; *янаг амрагийн дуу;* 2. хамгийн дотно хайртай.

ЯНАГД у р г а м а л том баг цэцэгтэй, өндөр ургадаг нэг зүйл ургамал.

ЯНАГЛАГЧ янаглах үйл гүйцэтгэгч.

ЯНАГЛАЛ янаглах үйлийн нэр; **дурлал янаглал** х о р ш..

ЯНАГЛАХ 1. бусдаас илүү дотно болгож үзэх амраглах; 2. бусдад тэсгэлгүй элэгсэж хайрлах, өршөөх.

ЯНАГЛУУЛАХ янаглахын үйлдүүлэх хэв.

ЯНАГУУН үзэгдэл юмсын чухам мөн чанар нь биш, гадаад талаас харагдах өнгөц байдал; *янагуун чанар; янагуун байдал.*

ЯНАГУУНХИ янагуун чанар, янагуун байдал; *янагуунхи үнэн.*

ЯНАГШ б и ч и г нааш; **янагш чанагш** х о р ш.; *янагш ирэх; аравнаас янагш.*

ЯНАГШИД б и ч и г наашид.

ЯНАГШЛАХ б и ч и г наашлах, нааш болох.

ЯНАГШЛУУЛАХ янагшлахын үйлдүүлэх хэв.

ЯНАГШИХ янаг болох, хүн амьтны нэгэндээ дурлан хайрлах нь үлэмжхэн болох.

ЯНАД б и ч и г наад; *янад этгээд; янад тал.*

ЯНАНГИ а м ь т а н толгой нь давх гэдэг загастай адил, биеийн байдал улаан сүүлт загастай адил бөгөөд далайд оршдог нэг зүйл загас.

ЯНАР б и ч и г наана; *ирэхийн янар;* **очихын** *янар; аравны янар.*

ЯНГАЛЬ а м ь т а н бие богширгын хиртэй шар хар цагаан алаг чандартай нэгэн зүйл жижигхэн шувуу.

ЯНГАЧ ямааран, янгууч.

ЯНГИА I янгирцаг.

ЯНГИА II: **янгиа дуу** нарийн хатан дуу.

ЯНГИНАХ 1. нарийн хатан дуу чимээ гарах; *янгинах дуу гарав; янгинах чимээ сонсдов;* 2. хангинах: **янгинах хангинах** х о р ш.; 3. юмны эрч хүч нэмэгдэх; *янгинатал хөлдөх; янгинатал өвдөх; янгинатал хүйтрэх;* 4. ягштал; *янгинатал тохиров; янгинатал хийв;* 5. шимшрэн өвдөх; *гар янгинаж өвдөөд унтсангүй.*

ЯНГИНУУЛАХ янгинахын үйлдүүлэх хэв.

ЯНГИР: **янгир ямаа** а м ь т а н зэрлэг ямаа.

ЯНГИРЦАГ малын нуруу ачихад хэрэглэх ачааны эмээл, янгиа.

ЯНГУУДАЙ зүрийн зулзага.

ЯНГУУЛАХ I янгууч зан байдал гаргах, эрх эмзэг байдал гаргаж тунирхах.

ЯНГУУЛАХ II хувцасны гадуур, өнгө болгож дан хувцас өмсөх.

ЯНГУУЛУУЛАХ янгуулахын үйлдүүлэх хэв.

ЯНГУУРХАХ янгуулж тунирхах, хэтэрхий янгууч зан байдал гаргах.

ЯНГУУРХУУЛАХ янгуурхахын үйлдүүлэх хэв.

ЯНГУУЧ өвдөх зэрэгт тунирхаж элдэв ааль авир гаргах хүн; *янгууч хүүхэд.*

ЯНГУУЧЛАХ янгууч зан байдал гаргах.

ЯНДАА шингэн ба үүрмэг юмыг хэмжих сав, их бага адилгүй; *айргийн яндаа; тарианы яндаа.*

ЯНДААЛАХ яндаагаар хэмжих.

ЯНДАЙ I яндаа.

ЯНДАЙ II ганс.

ЯНДАН (Г) I хулан, утаа дамжуулан гаргах хоолой; *яндан хөвлөгч .*

ЯНДАН II дохио өгөхөд зориулан дуугаргах механик хоолой; *яндан дуугаргах; есөн цагийн яндан; яндангийн дуу.*

ЯНДАН III эцэнхий туранхай; *яндан морь*

ЯНДАХ 1. юмыг яндаа саваар хэмжих; *айраг яндах;* 2. саванд юм дүүрэн болох; *ус савандаа яндах; хонь хурга хотондоо яндах.*

ЯНДУАН нэгэн зүйл торгомсог бараа.

ЯНДУУЛАХ яндахын үйлдүүлэх хэв.

ЯНЖУУР цаасанд хуйлсан нэгэн зүйл тамхи.

ЯНЗ (АН) 1. овор дүр, хэв хэлбэр, байдал төлөв; **янз байдал, янз хэлбэр, янз маяг, янз үзэмж** х о р ш.; *янз бүрийн; олон янзын; ямар янзаар хийх юм бэ?* 2. юмны гадаад талд гоёл чимэглэл болгож хийсэн зүйл; **янз чимэг, янз гоёл** х о р ш.; *байшингийн янз; цонхны янз; хаалганы янз; янз сайтай;* **янз оруулах** (юмыг янз сайтай, аятай үзэмжтэй болгож янзлах); 3. хүний зан, төрх; *янзын зан гаргах;* **янз гаргах** (а. бусдад муу зан ааш гаргах; б. юманд уг байдлаас дээрдүүлж үзэмж оруулах); **янзы нь үзэх** (бусдын саная байдлыг мэдэхээр хөндөж турших); 4. хэвийн байдал; *өвчний байдал ч янзандаа л байна; хуучин янзаараа л ажил хийж байна;* 5. хачин сонин; *би нэг янзын юм үзлээ; янз янзын юм сонсогдох л юм; янзын амьтан.*

ЯНЗАГА зээр, сүүлтэй, зүр зэрэг гөрөөсний зулзага.

ЯНЗАГАЛАХ янзага төрүүлэх.

ЯНЗГҮЙ 1. юмны үзэмж хэлбэр байдал муутайгий нь; *хэв янзгүй байшин;* 2. бусдад муу зан ааш гаргах буюу тоомсорлох байдалгүй байгаагий нь; *янзгүй байна; ирэх янзгүй.*

ЯНЗЛАГ юмны баахан янзтайгий нь, янз хэлбэр сайтай.

ЯНЗЛАХ 1. юмыг үзэмжтэй аятай сайн болгох; *юмаа янзлах; гэрээ янзлах;* 2. нэгэн тийш болгох; *ажлаа янзлах.*

ЯНЗЛУУЛАХ янзлахын үйлдүүлэх хэв.

ЯНЗТАЙ үзэмжтэй, янз маяг сайтай.

ЯНТАЙ бэх будаг зуурах сав; *бийр янтай бэх будаг, бичгийн хэрэглэл цөм бүрэн* (ерөөлөөс).

ЯНХАН үнэ хэлэлцэж явалдах эмэгтэй; *янхан болох;* **янхны газар** (янхны байрлах орон газар).

ЯНХИГАНАХ янхигар юмны янхига янхига хөдлөх.

ЯНХИГАР 1. амьтны турьхэн болоод яс биетом ханхар; *янхигар биетэй хүн;* 2. эд юмны овор хэлбэр муутай томы нь; *янхигар гэр.*

ЯНХИЙХ янхигар болох.

ЯНХИЛЗАХ янхигар юмны янхис янхис хөдлөх.

ЯНХИР янхигар, данхигар; *янхир өвгөн; янхир эвэр.*

ЯНЦАГЛАХ хэвэл дүүрэх буюу амьсгал давхцах зэрэгт сүйлэглэн дуу гарах; *янцаглан хөрвөөх.*

ЯНЦАГЛУУЛАХ янцаглахын үйлдүүлэх хэв.

ЯНЦГААХ 1. адууны ижил төрлөө эрэх дуудах зэрэгт хангинатал уртхан дуу гаргах; *морь янцгаах;* 2. элээ шувууны дуугарах; *элээ янцгаах.*

ЯНЧААН х у у ч и р с а н мөнгөн төгрөг; *хятад янчаан; орос янчаан.*

ЯНШАА хүний үг олон, яршигтайгий нь; *яншаа эмгэн.*

ЯНШВАР яншаа.

ЯНШИХ яншаа хүний дэмий олон үг хэлэх; **үглэх янших** х о р ш..

ЯНШУУЛАХ яншихын үйлдүүлэх хэв.

ЯНШУУР яншаа, яншдаг.

ЯР I хүн амьтны арьсанд болон салст бүрхэвчинд хорт хавдар гарах, нэвчих вээр шүүс цувах, эсвэл нясууран шархлах халдварт өвчний нэр; *яр гарах;* **тэмбүү яр** (өнгөний нэгэн зүйл халдварт өвчин).

ЯР II гол модонд хөндлөн хадагдсан модны гишүүний язгуур; *модны яр; яртай модны яран дундуур.*

ЯРАА I 1. ярагдсан газар; 2. усанд ямар нэгэн шалтгаанаас гарсан ар буюу хөвөс; *усны яраа.*

ЯРАА II: **яраа жараа** жаран оронтой тооны нэр, тоолшгүй ч гэнэ.

ЯРААЛАХ усанд ар, хөвөс дэгдэн гарах; *ус яраалах.*

ЯРААТАХ усанд яраа гарах.

ЯРААТУУЛАХ яраатахын үйлдүүлэх хэв.

ЯРАВГАНАХ 1. байн байн ярвайх; 2. ш и л ж с э н хээнцэр дээгүүр, ихэмсэг зан байдал гаргах; 3. арзганах; *өт хорхой яравганах.*

ЯРАВГАНУУР их зантай, яравгар.

ЯРАВГАР хямсгар, их зантай; *нэг л их зантай яравгар амьтан явах болж билээ.*

ЯРАГ яраглах үйлийн нэр; *яраг хүн; яраг мал.*

ЯРАГЛАХ 1. хүн амьтанд эвэршээл тохиолдох, бачимдан янцаглах; **янцаглах яраглах** х о р ш.; 2. хүн ба мал адгуусны унтахдаа янцаглан амьсгах; *яраглаад унтаж чадахгүй байх.*

ЯРАЛЖ салхинаас долгилж гарсан усны хунираа; *усны яралж; усанд яралж гарах.*

ЯРАЛЖЛАХ усанд яралж хунираа дэгдэн гарах; *ус яралжлах.*

ЯРАЛЗАХ гялалзам өнгөтэй буюу олон юмны харагдах хөдлөх байдал; *шүд нь яралзах; олон амьтан яралзаж харагдана.*

ЯРАЛЗУУЛАХ яралзахын үйлдүүлэх хэв.

ЯРАМ амт халуун, мах холимогт хольж иддэг нэгэн зүйл үр, эмнэлэгт хэрэглэдэг, хуажуу ч гэдэг; **ярам мод** у р г а м а л (ац салаанд сондуу үлэмж, навч хайлсны навчтай адил, үрийг ярам буюу хуажуу гэнэ).

ЯРАХ 1. юмыг журамнан хагалах ба юмны хоёр тийш зайлсхийх; **ярах хагагах** х о р ш.; *газрыг хагалж ярах; арьс махыг оглон ярах; үсий нь ярах; цугларсан хүмүүсийг хойш ярах;* 2. нээх, онгойлгох; *хөшиг ярах; энгэрээ ярах; хормойгоо ярах.*

ЯРВАЙЛГАХ ярвайхад хүргүүлэх.

ЯРВАЙХ яравгар болох.

ЯРВАЛДАХ ярвалзах.

ЯРВАЛЗАХ яравгар юмны ярвас ярвас хөдлөх.

ЯРВИГ яршиг, төвөг, бэрхшээл; *ярвиг ихтэй ажил; ярвиг бага.*

ЯРВИГГҮЙ төвөг бэрхшээлгүй.

ЯРВИГЛАХ ярвиг яршиг удах; *ялихгүй юманд ярвиглах хэрэг юу вэ?*

ЯРВИГТАЙ ярвиг яршиг ихтэй, төвөгтэй; *ярвигтай яриа.*

ЯРГА нядлага; **ярганы газар** (мал нядлах газар).

ЯРГАЙ у р г а м а л уулын хад хавчил газар буталж ургадаг нэгэн зүйл мод; *яргай ташуур.*

ЯРГАЛАХ ярга хийх, алах, нядлах.

ЯРГАХ I 1. амьтны газрыг эрэн нүх хийж цаашлах явах; *тарвага яргах;* 2. хүний ямар нэгэн үйл ажлын төлөө марган тэмцэлхийлж, авд тавьж өгөхгүй булаалдан эсэргүүцэх; *яргаж маргах;* 3. морь малын гэнт зогсохийж түдэх, ухрах; *морь яргах.*

ЯРГАХ II нүдэн дотор хатгалах мэт өвдөх; *нүд яргах.*

ЯРГАЧИН 1. мал нядлах хүн; *мал нядлах газрын яргачин;* 2. ш и л ж с э н алагч талагч; *яргачин фашист.*

ЯРГИА 1. дууны хатан аягүйгий нь; 2. үглээ, яншаа.

ЯРИГЛАХ 1. зовуурилах, яраглах; 2. ярвиглах.

ЯРГИХ I яргиа болох, янших; **яргих янших** х о р ш.; *нохой яргих.*

ЯРГИХ II дэвсгэр ширдэг нимгэдэж дороос нухаж хатуудах; *ор яргих; сандал яргих.*

ЯРГУЙ у р г а м а л хээр тал бэл газраар элбэг ургадаг бөгөөд хавар эрт цэцэглэдэг, холгсон цэцгийн язгуурын хөх шар өнгийн цэцэгтэй ургамлууд, малд сайн чанарын тэжээл болно.

ЯРГУЙЖИН у р г а м а л сийрэг хар модон ой, шугуйгаар ургадаг, холтсон цэцгийн язгуурын цагаан өнгийн цэцэгтэй олон наст ургамал, цагаан яргуй ч гэдэг.

ЯРДАГ амьтны хэдэрлэх хэвцэглэх адар зангайгий нь; *ярдаг нохой; яртай модны яран дундуур, ярдаг хүний шилэн дундуур* х у у ч; **ярдаг хөдлөх** (амьтны хэрдэг хэвцэг зан хөдлөх).

ЯРДАГЛАЛ ярдаглах үйлийн нэр.

ЯРДАГЛАХ ярдаг зан ааш гаргах, адайр зан гаргах; **ярдаглах хэвцэглэх** х о р ш..

ЯРДАГЛУУЛАХ ярдаглахын үйлдүүлэх хэв.

ЯРДАЙЛГАХ ярдайхад хүргүүлэх.

ЯРДАЙХ ярдгар болох.

ЯРДГАР шазайж харагдах нь, шазгар.

ЯРЗАЙЛГАХ ярзайхад хүргүүлэх; *шүдээ ярзайлгах; оёдлы нь ярзайлгах.*

ЯРЗАЙХ 1. хүн амьтны уруулаа сөхөж шүдээ ил гаргах; *шүд нь ярзайх; нохой ярзайж архирах;* 2. юмны ярзгар болох буюу ярзгар төлөв нь үзэгдэн байх, шазайх ч гэнэ; *оёдол нь ярзайх;* 3. хүний хэдэр хэвцэг зан байдал гаргах; *хэвцэглэж ярзайхын хэрэггүй.*

ЯРЗАЛЗАХ 1. ярзгар хүний байн байн шүдээ илрүүлэх; 2. нохой сүр үзүүлж шүдээ баахан баахан ил гаргах; 3. бяцхан олон амьтны үймэн хөдлөх.

ЯРЗАСХИЙХ 1. дуугүйгээр шүдээ баахан

гаргах; *ярзасхийж инээх;* 2. түр өчүүхэн баахан ярзайх.

ЯРЗГАНАХ ярзгар юмны ярзга ярзга хөдлөх.

ЯРЗГАР 1. амьтны уруул ойртохгүй шүд үзэгдэх; 2. юмны оёдлын утас нягт жигдийг ба арзгар; 3. шазгар.

ЯРИА (Н) 1. илтгэн өгүүлэх үг; **уг яриа** х о р ш.; *яриа хийх, бидэнд сайхан яриа хийж өгөө;* **ярианы хэл** (утга зохиолын хэлний хэм хэмжээнд тодий л үл хамаарагдах өдөр тутмын энгийн хэл); 2. дэмий олон үг дэлгэж авд зогсохгүй хүн; **яриа чалчаа, яриа хөөрөө** х о р ш.; *яриа хүн.*

ЯРИАГҮЙ 1. дуугай, үг яриа муутай; *яриагүй хүн;* 2. ярихын аргагүй, шалтгаангүй; *яриагүй сайн эд; яриагүй муу хийцтэй.*

ЯРИАТАЙ 1. үг яриа ихтэй; *чи яриатай хөөрөөтэй байж өгөөч дөө;* 2. будлиантай, маргаантай; *энэ ч нилээд яриатай зүйл байна даа.*

ЯРИГ нөрж ярьдаг зантайгий нь; *дэндүү яриг хүн шүү.*

ЯРИГДАХ 1. ярихын үйлдэгдэх хэв; 2. хэтэрхий яриг болох.

ЯРИГЛАХ нөрж ярих, нуршин хэлэлцэх, ярвиглах.

ЯРИЛЦАГЧ ярилцах үйл гүйцэтгэгч.

ЯРИЛЦАХ ярихын үйлдэлцэх хэв; *уг зүйлийг ярилцан тохиролцов*

ЯРИЛЦУУЛАХ ярилцахын үйлдүүлэх хэв.

ЯРИМГАЙ ярьж сурсан, хэлэмгий.

ЯРИМТГАЙ ярих их дуртай, яримхай.

ЯРИМХАЙ яримтгай.

ЯРИУЛАХ ярихын үйлдүүлэх хэв, ярихад хүрүүлэх; *партизаны дурдатгалыг яриулах; үзсэн харсныг яриулах.*

ЯРИХ хүний хоорондоо хэлэлцэх; **ярих хэлэх, ярих хөөрөх** х о р ш.; *ярьж суух; ярьж тохирох; ярьж хэлэх хэрэгтэй.*

ЯРТАЙ яр бүхий, яр өвчин бүхий; *яртай мод.*

ЯРТАЙХ ярвайх; **ярвайх яртайх** х о р ш..

ЯРТАХ яр бий болох, яр гарах.

ЯРТГАР яравгар.

ЯРТУУЛАХ яртахын үйлдүүлэх хэв.

ЯРУУ 1. уянгат, сонголонтой сайхан дуу; *яруу дуу; цээлхэн яруу хоолойгоор дуулав; хөгжмийн яруу эгшиг;* **яруу тунгалаг найрал хөгжим** (чавхдаст, дэлдэх, үлээвэр хөгжмийн зэвсгээр бүрдсэн нэг зүйл найрал хөгжим); 2. утга уянга; **яруу найраг** (айзам хэмжээнд тохируулан зохиосон шүлгийн зохиол); **яруу найрагч** (яруу найргийн зүйлд мэрэгжсэн хүн): **яруу найрлага** (бичиг зохиолын утга тодорхой, санаа агуулга нарийн зохицонгүй, үг өгүүлбэр уран найралтайгий нь); ☆ **яруу алдар** (олонд алдаршсан гавьяа, авьяас; цуу; *яруу алдарт манай ардын цэрэг).*

ЯРУУЛАГ элжигний өөр нэр.

ЯРУУЛАХ 1. ярахын үйлдүүлэх хэв; 2 ярагдах.

ЯРУУХАН яруу, нилээд яруу; *яруухан хоолойтой хүн; яруухан дуутай шувуу.*

ЯРХАЙ а м ь т а н хүр хорхойн адил, модны навч иддэг, мөн ширхэг гаргаж үүр хийдэг, чангарсан хойно эрвээхий болж хувилдаг нэг зүйл шавьж.

ЯРХИЙХ I зарим юмны унаж хэмхрэхэд гарах чимээ.

ЯРХИЙХ II 1. хүний хэвцэглэн эсэргүүцэх; *урьдаас ярхийх хэрэг байна уу чамд?* 2. нохой мэтийн уурсаж хуцах, архирах; *ян шувуу ярхийх, ясан хүзүү гозос хийх* (оньсго).

ЯРШИГ саад, түвэг, ярвиг; **яршиг түвэг** х о р ш.; *яршиг түвэг болох, яршиг яршиг би хийж чадахгүй.*

ЯРШИГГҮЙ түвэг, бэрхшээлгүй хялбар.

ЯРШИГЛАХ түвэгтэй бэрхшээлтэй үйл ажил үүсгэн ярвиг гаргах.

ЯРШИГТАЙ түвэгтэй, алжууралтай, бэрхшээлтэй; *чи олон юм яриад байдаг ямар яршигтай нөхөр вэ?*

ЯРШИХ яр нэмэгдэн ихдэх ба ярны толгой хатуурах.

ЯРШУУЛАХ яршихын үйлдүүлэх хэв.

ЯС (АН) I 1. хүн амьтны махны дотоод дахь хатуу зүйл; *сүүжний яс; загасны яс; ясан савх; нэр хугарахаар яс хугар* х у у ч; **яс нясгах** (хүүр барих); **яс барих** (нас барсан хүнд хүрч оршуулах); **ясаа тавих** (оршуулах); **яс амрах** (аливаа үйлийг удаан хийж түүнээс салах): **яс хагацах** (а. төрөх; б алив хүнд хүчир ажлаас суллагдах); **яс хавтайх** (айх эмээх, ичих зовох; *аавыг загнах байх гэж л яс хавтайж байлаа; олон хүний өмнө*

учир утгагүй л юм хэлчих болов уу гэж яс хавтайж байв); **яс хаях** (хоёр этгээдийг хооронд нь муудуулах хэрэлдүүлэхийн тулд арга мэх хэрэглэх); **ясаа цайх** (зовлон эдлэх, тамаа цайх ч гэдэг); **яс арьс болох** (хүн амьтны ихэд турах; *яс арьс болоод танигдахаа байв);* **ясан хэлхээ** (маш туранхай); **яс цоож** (чангалан хорих шорон); **яс гаргах, яс заах** (а. мэрийх чарайх: б. хатуужин тэсвэрлэх); **ясан бариа** (сүрье, тэмбүү зэрэг өвчнөөс ясанд бий болох бороо); **ясан шүд** (адууны дээд дорд шүдний гол дундах хонхор нь цөм арилж гүйцсэний нь); ☆ **яс мод** (байшин барилга зэргийн юмны гол их бие болж байгаа мод); 2. зарим жимс, жимсгэний дотор байх хатуу цөм болон зарим үр жимсний хатуу хальс; *жимсэний яс; самрын яс; хушганы яс;* 3. овог үндэс, удам угсаа; **яс үндэс** х о р ш.; *та ямар ясны хүн бэ? яс үндсээ мартах;* **яс махны тасархай** (төрөл садан; *манай яс махны тасархай).*

ЯС II чанар, ханилгаа; *яс муутай эд. ясы нь таних; хүний ясаар мууxан хүн;* **ясаа гаргах** (хүний сайн муу чанар байдал нь илрэх).

ЯСАРХАГ 1. амьтны бие чацархаг том; 2. юмны яс чанар арай сайтайгий нь.

ЯСАРХУУ 1. ясархаг; 2. яс шиг.

ЯСГҮЙ 1. яс байхгүй; 2. нөхрийн ханш ханилгаа чанар муу; *ясгүй хүн; ясгүй нөхөр.*

ЯСДАХ хэтэрхий яс болох.

ЯСЖИХ 1. ястай болох, яс болох; 2. яс чанар нь сайжрах.

ЯСЖУУЛАХ ясжихын үйлдүүлэх хэв.

ЯСЛАГ 1. ясархаг; 2. яс сайтай; **яслаг жүрж** у р г а м а л (амтлаг жүржийн адил болоод арай жижиг, амт хүчтэй нэгэн зүйл жүрж).

ЯСЛАХ юманд яс хийх.

ЯСРАХ яс болох.

ЯСТ яс бүхий; *яст жимс жимсгэнэ;* **яст мэлхий** а м ь т а н (мөлхөгч амьтны нам, дулаан оронд төрнө, гадууpаа эвэрлэг бүрхүүл ясан хуягтай, хөл богино, удаан явдаг нэгэн зүйл амьтан).

ЯСТАЙ 1. яс бүхий юм; 2. хүн малын чадал тэнхлүүн чадамгайгий нь; 3. эд барааны эдэлгээ чанар сайтайгий нь; 4. нөхрийн ханш сайтай.

ЯСТАН овгийн байгуулал задарсан түүхэн явцад бий болох хүмүүсийн нийтлэг байдал; *ястны хэл.*

ЯТГА олон чавхдасанд тэвх тулж хөгжимдөг хөгжмийн зэвсэг; *ятгаар хөгжимдөх; ятга цохих;* **ятга шаазгай** а м ь т а н (ой тайгад оршдог, улаан шар толгойтой, хушуу хар, далавч нь цэнхэр хөх бөгөөд цагаан бидэртэй, өвөлждөг нэгэн зүйл шувуу, ургамлын үндэс ба жимс шавьж зэрэг зүйл иднэ).

ЯТГАГЧ ятгах үүрэг гүйцэтгэгч.

ЯТГАДАХ ятга хөгжим цохих.

ЯТГАДУУЛАХ ятгадахын үйлдүүлэх хэв.

ЯТГАЛ үйл хэргийн учир холбогдлыг дурдан сануулж засч залруулах үг; *ятгал үг.*

ЯТГАЛГА ятгах үйлийн нэр; *ятгалга явуулах.*

ЯТГАЛИГ ерийн ятгаас арай бага хэмжээтэй, наймаас арван чавхдастай хөгжмийн зэвсэг.

ЯТГАМЖ ятгасан нь; *ятгамж үг.*

ЯТГАМЖЛАХ сургамж болгон хэлж ятгах.

ЯТГАХ 1. бусдад юмны учир чанар, хор холбогдлыг ухуулан өгөх; 2. хүнийг буруу мууд удирдан дагуулахын тул ухуулах; 3. адуу малыг билчээрт тогтоох; *мал ятгах.*

ЯТГУУЛАХ 1. ятгахын үйлдүүлэх хэв; 2. ятгагдах.

ЯТУУ а м ь т а н гургуултай адил боловч бяцхан, сүүл охор нэгэн зүйл шувуу, заримын хушуу улаан байх нь бий, авлаж ашиглана.

ЯТУУЛИГ а м ь т а н ятуутай төстэй, гоёмсог сайхан нэг зүйл шувуу.

ЯХИР I бусдын хийсэн юм санаанд нь тохирдоггүй, юуханд гэсэн нуршин ярвиглах чамбай, хэцүү хүн; **яхир шахир** (хөнгөн ялиагүй, аахар шаахар ч гэнэ).

ЯХИР II: **яхир дуу** дуу чимээний хахир хатууг нь.

ЯХИРДАХ хэтэрхий яхир болох.

ЯХИРЛАХ яхир зан байдал гаргах.

ЯЦ а м ь т а н далайд төрөх, ясгүй нэгэн зүйл загас.

ЯШИЛ у р г а м а л говь хангай нутагт асга хадтай газраар ургадаг, том сөөг ургамал, мод нь хатуу бөгөөд улаан хүрэн өнгөтэй, аливаа эдлэл хийхэд хэрэглэнэ.

ЯШИН яшин тэглэй а м ь т а н тэглэй шувууны нэгэн зүйл.

ЭНЭ ТОЛИЙГ АШИГЛАГЧИД АА!

Тус толь бичгийг хэвлэх явцад хааяа зарим нэг хоёр үг гээгдсэн, зарим нэгэн үг үсэг ташаарсан, жижиг үсгээр байвал зохих үг үсэг том үсэг болсон зэрэг үсгийн дүрмийн зөв бичлэгийн алдаа мадаг мэр сэр байгаа боловч түүнээс болж утгын талаар ноцтой алдаа гармааргүй болох тул тусгайлан залруулга хийсэнгүй.

Я. ЦЭВЭЛ

МОНГОЛ ХЭЛНИЙ ТОВЧ ТАЙЛБАР ТОЛЬ

Редактор **Х. Лувсанбалдан**
Техник редактор **Я. Бадарч**
Хянагч **Б. Уламбаяр**
Ц. Дамбадаржаа

* * *

Өрөлтөнд 1965 оны 2 дугаар сарын 13-нд орж
Хэвлэлтэнд 1966 оны 1 дүгээр сарын 20-нд шилжсэн
Цаасны хэмжээ 84×108 $^{1}/_{16}$ Хэвлэсэн тоо 20 000
Хэвлэлийн хуудас 57 А—15177 Захиалга № 140

Үнэ 19 төг.

* * *

Д. Сүхбаатарын Нэрэмжит Хэвлэлийн Комбинатад **хэвлэв.**
Улаанбаатар Д. Сүхбаатарын нэрэмжит талбай, 2